

**THE BOOK OF  
MORMON**

**MONGOLIAN – ENGLISH  
PARALLEL EDITION**

Version 1, published April 2023. [bencrowder.net/book-of-mormon-parallel-edition/](http://bencrowder.net/book-of-mormon-parallel-edition/)

This parallel edition © 2023 Benjamin Crowder. All rights reserved. You have permission to print this document for your own use. For other uses, send requests to [ben.crowder@gmail.com](mailto:ben.crowder@gmail.com).

Text of the Book of Mormon © 2023 Intellectual Reserve, Inc. All rights reserved.

The text of this edition is licensed from The Church of Jesus Christ of Latter-day Saints with the following disclaimer: *The Product offered by Benjamin Crowder is neither made, provided, approved, nor endorsed by, Intellectual Reserve, Inc. or The Church of Jesus Christ of Latter-day Saints. Any content or opinions expressed, implied, or included in or with the Product offered by Benjamin Crowder are solely those of Benjamin Crowder and not those of Intellectual Reserve, Inc. or The Church of Jesus Christ of Latter-day Saints.*

# МОРМОНЫ НОМ НИФАЙН ЯЛТСУУДААС АВАГДАЖ МОРМОНЫ ГАРААР ЯЛТСУУД ДЭЭР БИЧИГДСЭН ШАСТИР ОРШВОЙ

Иймийн тул, энэ нь Нифайн хүмүүсийн, мөн түүнчлэн Леменчүүдийн цэдгийн хураангуйлал юм— Израилын угсааны үлдэгдэл болох Леменчүүдэд мөн түүнчлэн Иудей болон харийнханд бичигдсэн болой—Зарлигийн замаар, мөн түүнчлэн бошиглолын мөн илчлэлтийн суу билгээр бичигдсэн бөлгөө—Мөн тэдгээр нь устгагдахгүй байж болохын тулд бичигдэн, лацдагдаж, мөн Их Эзэний тул далд хадгалагдсан бөлгөө—Бурханы бэлэг болон хүчээр эиэ нь орчуулагдахын тулд ирэх болно—Моронайн гараар лацдагдан, мөн зохих цагтаа харийнханаар дамжин улиран ирэхийн тул Их Эзэний тул далд хадгалагдсан буюу—түүний орчуулга нь Бурханы бэлгээр болой.

Тэднийг тэнгэрт хүрэх цамхаг барьж байхад нь, Их Эзэн хүмүүсийн хэл яриаг будлиулсан тэр цагт тараагдсан тэдгээр, Жаредын хүмүүсийн цэдэг болох, Иферийн номноос түүнчлэн авагдсан хураангуйлал бөлгөө—мөн Их Эзэний гэрээнүүдийг тэд мэдэж болохын тул, тэд үүрд зайлуулагдахгүй байхын тул Их Эзэн тэдний өвөг дээдэст ямар агуу зүйлүүдийг хийж өгснийг Израилын угсааны үлдэгдэлд үзүүлэх тэрхүү; мөн түүнчлэн өөрийгөө бүх үндэстнүүдэд үзүүлэх тэр Есүс бол Христ, Мөнхийн Бурхан хэмээн Иудей болон харийнханд итгүүлж—Мөн эдүгээ, хэрэв буруу буй бөгөөс тэдгээр нь хүмүүний алдаа бөлгөө; иймийн тул, та нар Христийн шүүлтийн суудлын өмнө толбогүй байж болохын тулд, Бурханы зүйлүүдийг бүү буруушаа.

# The Book of Mormon An Account Written by the Hand of Mormon upon Plates Taken from the Plates of Nephi

Wherefore, it is an abridgment of the record of the people of Nephi, and also of the Lamanites—Written to the Lamanites, who are a remnant of the house of Israel; and also to Jew and Gentile—Written by way of commandment, and also by the spirit of prophecy and of revelation—Written and sealed up, and hid up unto the Lord, that they might not be destroyed—To come forth by the gift and power of God unto the interpretation thereof—Sealed by the hand of Moroni, and hid up unto the Lord, to come forth in due time by way of the Gentile—The interpretation thereof by the gift of God.

An abridgment taken from the Book of Ether also, which is a record of the people of Jared, who were scattered at the time the Lord confounded the language of the people, when they were building a tower to get to heaven—Which is to show unto the remnant of the house of Israel what great things the Lord hath done for their fathers; and that they may know the covenants of the Lord, that they are not cast off forever—And also to the convincing of the Jew and Gentile that JESUS is the CHRIST, the ETERNAL GOD, manifesting himself unto all nations—And now, if there are faults they are the mistakes of men; wherefore, condemn not the things of God, that ye may be found spotless at the judgment-seat of Christ.

# НИФАЙН НЭГДҮГЭЭР НОМ

## ТҮҮНИЙ ХААНЧЛАЛ БА ТОХИНУУЛАЛ

*Лихай болон түүний эхнэр Сариа, мөн түүний (ахмадаас дэслэн) Леман, Лемүел, Сам болон Нифай хэмээн нэрлэгдэх дөрвөн хөвгүүний шастир оршвой. Лихай хүмүүст тэдний ёсон бус үйлийн тухай бошигсноос тэд түүний амийг бүрэлгэхээр эрэлхийлэн буй тул Иерусалимаас одохыг Их Эзэн түүнд сэргийлэн сануулжээ. Тэр гэр бүлийнхээ хамт гурав хоногийн турш аглаг буйдад зорчив. Нифай ах нараа аваад иудейчүүдийн цэдгийн төлөө Иерусалимын зүг буцсан болой. Тэдний зүдгүүрүүдийн шастир оршвой. Тэд Ишмил гэгчийн охидыг эхнэр болгон авав. Тэд гэр бүлээ авч аглаг буйд тийш одов. Аглаг буйд дахь тэдний зовлон ба зүдгүүр. Тэдний аялсан замнал. Тэд их усанд ирэв. Нифайн ах нар түүнийг эсэргүүцэв. Тэрээр тэднийг шившиглэж, мөн усан онгоц босгов. Тэд уг нутгийг Өгөөмөр хэмээн нэрийдэв. Тэд их усыг гатлан амлагдсан нутагт хүрэв гэхчилэнгээр өгүүлэх ажгуу. Энэ нь Нифайн шастирын дагуу; эсвээс өөрөөр хэлбэл, би, Нифай, энэхүү цэдгийг бичиглэв.*

### 1 Нифай 1

- 1 БИ, Нифай, буянт сайн эцэг эхээс мэндэлсний учир, тиймийн тул миний бие эцгийнхээ бүхий л эрдэм мэдлэгт зарим талаар сургагдсан байв; бас амьдралынхаа турш өчнөөн зүдгүүрийг туулсан хэдий ч, амьдралынхаа бүхий л өдрүүдэд би Их Эзэний өндөр их ээл хишгийг хүртэж, тийм ээ, Бурханы нууц болон сайн сайхны агуу их мэдлэгийг олсны учир, тийнхүү би өөрийн өдрүүдэд үзэж үйлдсэнээ цэдэглэх бөлгөө.
- 2 Тийм ээ, би иудейчүүдийн эрдмээс мөн египетчүүдийн хэлнээс боловсорсон эцгийнхээ хэлэн дээр цэдгийг товчоолох ажгуу.

# The First Book of Nephi

## His Reign and Ministry

*An account of Lehi and his wife Sariah, and his four sons, being called, (beginning at the eldest) Laman, Lemuel, Sam, and Nephi. The Lord warns Lehi to depart out of the land of Jerusalem, because he prophesieth unto the people concerning their iniquity and they seek to destroy his life. He taketh three days' journey into the wilderness with his family. Nephi taketh his brethren and returneth to the land of Jerusalem after the record of the Jews. The account of their sufferings. They take the daughters of Ishmael to wife. They take their families and depart into the wilderness. Their sufferings and afflictions in the wilderness. The course of their travels. They come to the large waters. Nephi's brethren rebel against him. He confoundeth them, and buildeth a ship. They call the name of the place Bountiful. They cross the large waters into the promised land, and so forth. This is according to the account of Nephi; or in other words, I, Nephi, wrote this record.*

### 1 Nephi 1

- 1 I, Nephi, having been born of goodly parents, therefore I was taught somewhat in all the learning of my father; and having seen many afflictions in the course of my days, nevertheless, having been highly favored of the Lord in all my days; yea, having had a great knowledge of the goodness and the mysteries of God, therefore I make a record of my proceedings in my days.
- 2 Yea, I make a record in the language of my father, which consists of the learning of the Jews and the language of the Egyptians.

- 3 Мөн миний үйлдэх тэрхүү цэдэг үнэн гэдгийг би мэднэ; басхүү би үүнийг өөрийн гараар үйлдэв; басхүү би үүнийг өөрийн мэдлэгээр бүтээх бөлгөө.
- 4 Учир нь улиран тохиох дор Иудейн хаан Зедикая засаглан суух анхны жилийн эхэнд (миний эцэг, Лихай, амьдралынхаа бүх өдрүүдэд Иерусалимд суурьшин байсан ажгуу); мөн чухамхүү тэр л онд олон бошиглогч хүмүүст хандан тэднийг нүглээ наманчлах ёстой, эс бөгөөс их хот Иерусалим устгагдах ёстойг бошиглож байсан ажгуу.
- 5 Иймийн тул улиран тохиох дор миний эцэг, Лихай, тэрээр урагш одох зуураа Их Эзэнд залбирав, тийм ээ, тэр ч байтугай бүх сэтгэл зүрхээрээ түмэн оныхоо төлөө залбирав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Их Эзэнд хандан залбирах үед, галан багана тодорч мөн түүний өмнө хэвтэх чулуун дээр тогтон үзэгдэв; мөн тэрээр ихийг үзэж бас сонсов; басхүү тэрбээр өөрийн үзэж, сонссон зүйлүүдийн улмаас үлэмж ихээр чичрэн дагжив.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Иерусалим дахь гэртээ буцав; чингээд Сүнс ба өөрийн үзсэн зүйлүүдийн улмаас догдлон байсны учир тэрээр биеэ ор дэвсгэртээ хадан байсан ажээ.
- 8 Мөн ийнхүү Сүнснээс болж сульдсаны учир, тэрбээр өөрийн биеэс халин үзэгдэлд зорчихуй дор, тэрээр тэнгэр нээгдэхийг үзсэн буюу, тэрээр өөрийн тунгааснаар асар тэнгэрт Бурханыг магтан дуулах тоо томшгүй олон тэнгэр элчээр хүрээлүүлэн Бурхан хаан сэнтийдээ залран буйг харжээ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Нэгэн бие асар тэнгэрээс доошлон буухыг, басхүү тэрээр түүний туяаран гэрэлтэх нь үдийн нарнаас ч хурц болохыг харсан ажээ.
- 10 Мөнхүү тэрбээр түүнчлэн түүнийг шадарлан буй өөр бусад арванхоёрыг харав, басхүү тэдний гэрэлтэх нь огторгуй дахь одноос ч үлэмж давуутай бөлгөө.
- 11 Мөн тэд доошлон ирж басхүү урагшлан дэлхийн гадаргуугаар одов, мөн тэргүүлэн буй нь ирж, басхүү эцгийн минь өмнө зогсоод, мөн нэгэн номыг түүнд өгөөд, түүнчлэн тэрбээр уг номыг уншвал зохилтой хэмээн тушаажээ.

And I know that the record which I make is true; and I make it with mine own hand; and I make it according to my knowledge.

For it came to pass in the commencement of the first year of the reign of Zedekiah, king of Judah, (my father, Lehi, having dwelt at Jerusalem in all his days); and in that same year there came many prophets, prophesying unto the people that they must repent, or the great city Jerusalem must be destroyed.

Wherefore it came to pass that my father, Lehi, as he went forth prayed unto the Lord, yea, even with all his heart, in behalf of his people.

And it came to pass as he prayed unto the Lord, there came a pillar of fire and dwelt upon a rock before him; and he saw and heard much; and because of the things which he saw and heard he did quake and tremble exceedingly.

And it came to pass that he returned to his own house at Jerusalem; and he cast himself upon his bed, being overcome with the Spirit and the things which he had seen.

And being thus overcome with the Spirit, he was carried away in a vision, even that he saw the heavens open, and he thought he saw God sitting upon his throne, surrounded with numberless concourses of angels in the attitude of singing and praising their God.

And it came to pass that he saw One descending out of the midst of heaven, and he beheld that his luster was above that of the sun at noon-day.

And he also saw twelve others following him, and their brightness did exceed that of the stars in the firmament.

And they came down and went forth upon the face of the earth; and the first came and stood before my father, and gave unto him a book, and bade him that he should read.

- 12 Мөнхүү улиран тохиох дор тэрээр уншихад, тэрбээр Их Эзэний Сүнсээр дүүргэгдсэн ажгуу.
- 13 Мөнхүү тэрээр уншаад өгүүллрүүн: Ай халаг, ай халаг Иерусалим минь, би чиний жигшүүрт үйлүүдийг харан байнам! Тийм ээ, мөн миний эцэг Иерусалимын тухай олон зүйлийг уншсан—энэ нь, бас тэндхийн оршин суугчид устгагдахыг; олон нь илдэнд эрсдэж, мөн олон нь олзлогдож Вавилонд хүргэгдэхийг болой.
- 14 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг олон агуу хийгээд гайхамшигт зүйлүүдийг харж бас уншаад, тэрээр уулга алдаж Их Эзэнд хандан: Таны үйлдэхүй дор ямар агуу хийгээд гайхамшигтай вэ, Ай Их Эзэн, Бүхнийг Чадагч Бурхан минь! Таны сэнтий өндөр тэнгэрт буй, мөн таны хүчин, басхүү сайн сайхан, мөн нигүүлсэл тань газар дэлхийн оршин амьдрагч бүхний дээр буй; мөн та нигүүлсэнгүй учир, танд ирэх тэдний мөхөхийг та үл тэвчих буйза! гэх мэт олон зүйлийг өгүүлэв.
- 15 Мөн эцгийн минь Бурханаа магтан дуулах хэл иймэрхүү байлаа; учир нь түүний бодгаль баясан басхүү бүх сэтгэл зүрх нь дүүргэгдэв; түүний үзсэн зүйлс, тийм ээ, Их Эзэн түүнд үзүүлсэн зүйлүүдийн улмаас бөлгөө.
- 16 Мөн эдүгээ би, Нифай, эцгийнхээ бичсэн зүйлүүдийн бүрэн шастирыг үйлдэхгүй, учир нь тэрээр өөрийн харсан үзэгдлүүд хийгээд зүүднээс олон зүйлийг бичиглэсэн, басхүү тэрбээр хүүхдүүддээ бошиглон мөн ярьсан олон зүйлийг бичиглэснийг нь би нэг бүрчлэн сийрүүлэн үйлдэхгүй буюу.
- 17 Харин би өөрийн өдрүүдэд үйлдсэнийхээ шастирыг үйлдэх болой. Болгоогтун, би эцгийнхээ цэдгийг хураангуйлан, би өөрийн гараар бүтээсэн ялтсууд дээрээ буулгав; иймийн тул бибээр эцгийнхээ цэдгийг хураангуйлсны төгсгөлд би амьдралынхаа шастирыг үйлдэх бөлгөө.
- 18 Тиймийн тул, Их Эзэн үлэмж олон ер бусын гайхамшигт зүйлүүдийг миний эцэг, Лихайд үзүүлсний дараа, тийм ээ, Иерусалимын устгалын тухай, болгоогтун, тэрбээр хүмүүсийн дунд орж, мөн өөрийн сонссон болон үзсэн зүйлүүдийн талаар тэдэнд бошиглон тунхаглаж эхэлснийг та бүгд мэдээсэй хэмээнэ би.

And it came to pass that as he read, he was filled with the Spirit of the Lord.

And he read, saying: Wo, wo, unto Jerusalem, for I have seen thine abominations! Yea, and many things did my father read concerning Jerusalem—that it should be destroyed, and the inhabitants thereof; many should perish by the sword, and many should be carried away captive into Babylon.

And it came to pass that when my father had read and seen many great and marvelous things, he did exclaim many things unto the Lord; such as: Great and marvelous are thy works, O Lord God Almighty! Thy throne is high in the heavens, and thy power, and goodness, and mercy are over all the inhabitants of the earth; and, because thou art merciful, thou wilt not suffer those who come unto thee that they shall perish!

And after this manner was the language of my father in the praising of his God; for his soul did rejoice, and his whole heart was filled, because of the things which he had seen, yea, which the Lord had shown unto him.

And now I, Nephi, do not make a full account of the things which my father hath written, for he hath written many things which he saw in visions and in dreams; and he also hath written many things which he prophesied and spake unto his children, of which I shall not make a full account.

But I shall make an account of my proceedings in my days. Behold, I make an abridgment of the record of my father, upon plates which I have made with mine own hands; wherefore, after I have abridged the record of my father then will I make an account of mine own life.

Therefore, I would that ye should know, that after the Lord had shown so many marvelous things unto my father, Lehi, yea, concerning the destruction of Jerusalem, behold he went forth among the people, and began to prophesy and to declare unto them concerning the things which he had both seen and heard.

19 Мөнхүү улиран тохиох дор тэдний талаар түүний гэрчлэн мэдүүлсэн зүйлүүдийн учир иудейчүүд түүнийг доромжлон элэглэв; учир нь тэрээр тэдний жигшүүрт хэргүүд болон тэдний ёс бусын үйлийг үнэнээр гэрчилж, мөн сонссон басхүү үзсэн зүйлүүд хийгээд түүнчлэн номноос уншсан зүйлүүд, Мессиагийн ирэх хийгээд түүнчлэн дэлхийн гэтэлгэлийг илэрхийгээр мэдүүлсэн гэдгийг тэрбээр гэрчилсэн болой.

20 Мөн иудейчүүд эдгээр зүйлийг дуулаад түүнд уурлан; тийм ээ, түүгээр үл барам тэднийг хөөн зайлуулж, чулуугаар шидэн хороосон, хөнөөж егүүтгэсэн тэрхүү эрт цагийн бошиглогчдын адилаар, бас тэд түүний амийг тэрчлэн үзэж, тэд амийг нь авахаар эрэлхийлсэн ажгуу. Гэвч болгоогтун, итгэлийнх нь учир бүр тэднийг аюулаас ангижрах чадалтай болтол нь хүчтэй болгохоор сонгосон бүгдийн дээр Их Эзэний нигүүлсэл байдгийг би, Нифай та нарт үзүүлэх болно.

And it came to pass that the Jews did mock him because of the things which he testified of them; for he truly testified of their wickedness and their abominations; and he testified that the things which he saw and heard, and also the things which he read in the book, manifested plainly of the coming of a Messiah, and also the redemption of the world.

And when the Jews heard these things they were angry with him; yea, even as with the prophets of old, whom they had cast out, and stoned, and slain; and they also sought his life, that they might take it away. But behold, I, Nephi, will show unto you that the tender mercies of the Lord are over all those whom he hath chosen, because of their faith, to make them mighty even unto the power of deliverance.

## 1 Нифай 2

- 1 Учир нь болгоогтун, улиран тохиох дор Их Эзэн эцэгт минь хэлэв, тийм ээ, бүр зүүд нойронд нь түүнд өгүүлсэн нь: Үйлдсэн зүйлүүдийнхээ учир Лихай чи адислагдсан нэгэн болой; бас итгэлтэй байж мөн миний чамд зарлигласан зүйлүүдийг чи энэ хүмүүст тунхагласны учир, болгоогтун, тэд амийг чинь авахаар эрэлхийлэх авай.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн миний эцэгт, бүр зүүд нойронд нь, тэрээр гэр бүлээ авч мөн аглаг буйд тийш одвол зохино хэмээн зарлиглажээ.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Их Эзэний үгийг дуулгавартай дагасан буюу, иймийн тул тэр Их Эзэн өөрт нь зарлигласнаар үйлдсэн ажгуу.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр аглаг буйд тийш одов. Мөн тэр өөрийн гэр, бас өвлөж ирсэн нутгаа, бас алт болон мөнгөө, бас үнэт зүйлсээ орхин, мөн гэр бүлийн хамт хоол хүнс, бас майхнаас өөр юуг ч эс аван аглаг буйдыг зорин одсон ажгуу.
- 5 Мөнхүү тэрээр Улаан тэнгисийн хөвөөнд ойр орших хязгаар нутагт уруудан ирэв; бас тэрээр Улаан тэнгисийн ойр орших хил хязгаарыг дагаж аглаг буйдад аялсан авай; басхүү тэрээр миний эх Сариа болон миний ах нар Лемел, Лемүел мөн Самаас бүрдсэн гэр бүлтэйгээ аглаг буйдад аялсан ажгуу.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэрээр гурав хоног аглаг буйдад аялаад, тэрбээр нэгэн хөндийд, уст голын дэргэд майхнаа босгов.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тахилын чулуун ширээ босгон, Их Эзэнд өргөл үйлдэн, бас Их Эзэн Бурхандаа талархлаа мэдүүлсэн авай.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эл голыг Лемел хэмээн нэрийдэв, мөн тэр нь Улаан тэнгист цутгадаг байв; мөн уг хөндий нь голын цутгаланд ойрхон байсан болой.
- 9 Мөн эцэг минь тэр голын ус Улаан тэнгисийн усны сан уруу шавхагдан юүлэгдэхийг хараад, тэрээр Лемелд хандаж, өгүүлрүүн: Ай чи энэ гол мэт бүхий л зөв шударгын сан уруу зогсолтгүй тэмүүлэх болоосой хэмээв!

## 1 Nephi 2

For behold, it came to pass that the Lord spake unto my father, yea, even in a dream, and said unto him: Blessed art thou Lehi, because of the things which thou hast done; and because thou hast been faithful and declared unto this people the things which I commanded thee, behold, they seek to take away thy life.

And it came to pass that the Lord commanded my father, even in a dream, that he should take his family and depart into the wilderness.

And it came to pass that he was obedient unto the word of the Lord, wherefore he did as the Lord commanded him.

And it came to pass that he departed into the wilderness. And he left his house, and the land of his inheritance, and his gold, and his silver, and his precious things, and took nothing with him, save it were his family, and provisions, and tents, and departed into the wilderness.

And he came down by the borders near the shore of the Red Sea; and he traveled in the wilderness in the borders which are nearer the Red Sea; and he did travel in the wilderness with his family, which consisted of my mother, Sariah, and my elder brothers, who were Laman, Lemuel, and Sam.

And it came to pass that when he had traveled three days in the wilderness, he pitched his tent in a valley by the side of a river of water.

And it came to pass that he built an altar of stones, and made an offering unto the Lord, and gave thanks unto the Lord our God.

And it came to pass that he called the name of the river, Laman, and it emptied into the Red Sea; and the valley was in the borders near the mouth thereof.

And when my father saw that the waters of the river emptied into the fountain of the Red Sea, he spake unto Laman, saying: O that thou mightest be like unto this river, continually running into the fountain of all righteousness!



- 10 Мөн түүнчлэн тэрбээр Лемүелд хандан, Ай Их Эзэний зарлигуудыг дагахдаа чи энэ хөндий мэт тууштай бас гуйвшгүй бас хөдөлшгүй байгаасай хэмээв!
- 11 Эдүгээ тэрээр эдгээрийг Лемен Лемүел хоёрын зөрүүд араншингийн учир өгүүлсэн ажгуу; учрыг болгоогтун эцэг нь зөнч байж, мөн өвлөгдөж ирсэн газраа, мөн алт болон мөнгөө, бас үнэт зүйлсээ орхин, тэднийг Иерусалим нутгаас гадагш дагуулан, аглаг буйдад амь өрсөх болгосон тул тэд эцгийн хэлсэн олон зүйлийг эсэргүүцэн бувтналдав. Мөн түүнийг зүрх сэтгэлийнхээ хоосон төсөөллийн улмаас ийнхүү үйлдэв хэмээн тэд хэлэлцжээ.
- 12 Мөн ийнхүү, хөвгүүдийн ахмад нь болох Лемен, Лемүел хоёр эцгийнхээ эсрэг бувтналдсан ажээ. Мөн, тэд өөрсдийг нь бүтээсэн Бурханы үйлсийг мэдээгүйн улмаас бувтналдсан болой.
- 13 Тэд бас их хот Иерусалим, бошиглогчдын хэлсэнчлэн устгагдаж болно гэдэгт итгэсэн нь үгүй. Мөнхүү тэд эцгийн минь амийг хөнөөхөөр эрэлхийлсэн Иерусалим дахь иудейчүүдийн адил байсан бөлгөө.
- 14 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг Лемүелийн хөндийд Сүнсээр дүүргэгдэж, тэднийг өөрийн өмнө бүх бие нь салгалан чичиртэл хүчтэйгээр сургамжлав. Мөн, тэрээр тэднийг дуугарч зүрхлэхгүй болтол нь мадалж, иймийн тул, тэд түүний зарлигийг дагах болов.
- 15 Мөн, эцэг минь майханд аж төрөн байв.
- 16 Мөн улиран тохиох дор би, Нифай, үлэмж балчир бага хэдий ч, бие ханхар хийгээд Бурханы нууцыг мэдэх асар их хүсэлтэй байсны учир, иймийн тул, би Их Эзэнд хандаж гуйн залбирав; мөн болгоогтун тэрбээр надад зочлов, бас зүрх сэтгэлийг минь зөөлөлөнсийн учир би эцгийн ярьсан бүх үгсэд итгэсэн авай; иймийн тул ах нарынхаа адил би түүнийг эсэргүүцсэн нь үгүй.
- 17 Мөн би Самд ярьж Их Эзэн Ариун Сүнсээрээ надад үзүүлсэн зүйлүүдийг түүнд мэдэгдэв. Мөнхүү улиран тохиох дор тэрбээр миний үгэнд итгэв.

And he also spake unto Lemuel: O that thou mightest be like unto this valley, firm and steadfast, and immovable in keeping the commandments of the Lord!

Now this he spake because of the stiffneckedness of Laman and Lemuel; for behold they did murmur in many things against their father, because he was a visionary man, and had led them out of the land of Jerusalem, to leave the land of their inheritance, and their gold, and their silver, and their precious things, to perish in the wilderness. And this they said he had done because of the foolish imaginations of his heart.

And thus Laman and Lemuel, being the eldest, did murmur against their father. And they did murmur because they knew not the dealings of that God who had created them.

Neither did they believe that Jerusalem, that great city, could be destroyed according to the words of the prophets. And they were like unto the Jews who were at Jerusalem, who sought to take away the life of my father.

And it came to pass that my father did speak unto them in the valley of Lemuel, with power, being filled with the Spirit, until their frames did shake before him. And he did confound them, that they durst not utter against him; wherefore, they did as he commanded them.

And my father dwelt in a tent.

And it came to pass that I, Nephi, being exceedingly young, nevertheless being large in stature, and also having great desires to know of the mysteries of God, wherefore, I did cry unto the Lord; and behold he did visit me, and did soften my heart that I did believe all the words which had been spoken by my father; wherefore, I did not rebel against him like unto my brothers.

And I spake unto Sam, making known unto him the things which the Lord had manifested unto me by his Holy Spirit. And it came to pass that he believed in my words.

- 18 Гэвч болгоогтун, Лемен, Лемүел хоёр миний үгсийг дуулахгүй байсан болохоор тийнхүү тэдний зүрх сэтгэлийн хатуугийн улмаас харамссаны учир би тэдний төлөө Их Эзэнд гуйн залбирлаа.
- 19 Ийнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хандаж, өгүүлэв: Адислагдсан буюу чи, Нифай, итгэлийнхээ учир, зүрх сэтгэлийн номхон байдалд байж, намайг хичээнгүйлэн эрэлхийлсний учир болой.
- 20 Миний зарлигийг дагахын хэрээр та нар дэгжиж, бас амлагдсан нутаг тийш удирдагдах бөлгөө; тийм ээ, бүр та нарт зориулан миний бэлтгэсэн тэр нутагт; тийм ээ, нутаг бүгдээс дээгүүр сонгомол нутагт буюу.
- 21 Мөн ах нар чинь чамайг эсэргүүцэхийн хэрээр, тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах болно.
- 22 Мөн чи миний зарлигуудыг дагахын хэрээр, ах нарынхаа багш хийгээд захирагч болгогдох ажгуу.
- 23 Учрыг болгоогтун, тэд намайг эсэргүүцэх тэр өдөр, би тэднийг зүхнэ, бүр зовлонт зүхлээр, мөн түүнчлэн чиний үр удам намайг эсэргүүцээгүй цагт тэднийг тэд давамгайлах хүчгүй байх болно.
- 24 Мөн хэрэв тэд миний эсрэг хандвал, тэд чиний үр удамд цээрлэл болон тэднийг дурсан сануулахаар өдөөн хатгах болно.

But, behold, Laman and Lemuel would not hearken unto my words; and being grieved because of the hardness of their hearts I cried unto the Lord for them.

And it came to pass that the Lord spake unto me, saying: Blessed art thou, Nephi, because of thy faith, for thou hast sought me diligently, with lowliness of heart.

And inasmuch as ye shall keep my commandments, ye shall prosper, and shall be led to a land of promise; yea, even a land which I have prepared for you; yea, a land which is choice above all other lands.

And inasmuch as thy brethren shall rebel against thee, they shall be cut off from the presence of the Lord.

And inasmuch as thou shalt keep my commandments, thou shalt be made a ruler and a teacher over thy brethren.

For behold, in that day that they shall rebel against me, I will curse them even with a sore curse, and they shall have no power over thy seed except they shall rebel against me also.

And if it so be that they rebel against me, they shall be a scourge unto thy seed, to stir them up in the ways of remembrance.

## 1 Нифай 3

- 1 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Их Эзэнтэй яриад, эцгийнхээ майханд буцаж ирэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр надад хандаж өгүүлсэн нь: Болгоогтун чамайг болон ах нарыг чинь Иерусалимд буцахыг Их Эзэн надад зарлиг болгосон нэг зүүдийг би зүүдлэв.
- 3 Учрыг болгоогтун, иудейчүүдийн цэдэг мөн түүнчлэн миний эцэг өвгөдийн угийн бичиг Лебенд буй бөгөөд тэдгээр нь гуулин ялтсууд дээр сийлбэрлэгдсэн ажгуу.
- 4 Иймийн тул чи болон ах нар чинь Лебений гэрт очиж, тэгээд ялтсуудыг эрэлхийлж, мөн аглаг буйд уруу нааш авчирвал зохино хэмээн Их Эзэн надад зарлигласан бөлгөө.
- 5 Мөн эдүгээ, болгоогтун ах нар чинь бувтналдаж тэднээс миний шаардсан зүйлийг хүнд бэрх гэгцгээв; гэвч болгоогтун тэднээс үүнийг шаардсан нь би биш, харин энэ бол Их Эзэний зарлиг.
- 6 Тиймийн тул яв, хүү минь, мөн чи дургүйцээгүй учир Их Эзэний адислалыг чи хүртэх болно.
- 7 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцэгтээ хандаж хэлрүүн: Их Эзэн өөрийн зарлигийг гүйцэлдүүлэх замыг тэдэнд зэхэлгүйгээр хүмүүний үрст зарлиг эс буулгана гэдгийг би мэдэх учраас би явж бас Их Эзэний зарлиг болсон тэр зүйлүүдийг биелүүлэх болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг эдгээр үгсийг сонсоод туйлаас баярлав, миний бие Их Эзэнээр адислагдсаныг мэдсэний учир болой.
- 9 Мөнхүү би, Нифай, басхүү миний ах нар Иерусалимын нутаг өөд явахаар, майхнаа авч, аглаг буйд дахь аяны харгуйг дагав.
- 10 Мөнхүү улиран тохиох дор бид Иерусалимын нутаг өөд очоод, би болон ах нар маань өөр хоорондоо зөвшилцсөн болой.
- 11 Мөн бид шавга орхин, Лебений гэрт хэн нь орвол зохихыг шодов. Мөнхүү улиран тохиох дор шавга Леменд тусав; тэгээд Лемен Лебений гэрт орж, түүнийг гэртээ сууж байхад нь түүнтэй ярилцсан болой.

## 1 Nephi 3

And it came to pass that I, Nephi, returned from speaking with the Lord, to the tent of my father.

And it came to pass that he spake unto me, saying: Behold I have dreamed a dream, in the which the Lord hath commanded me that thou and thy brethren shall return to Jerusalem.

For behold, Laban hath the record of the Jews and also a genealogy of my forefathers, and they are engraven upon plates of brass.

Wherefore, the Lord hath commanded me that thou and thy brothers should go unto the house of Laban, and seek the records, and bring them down hither into the wilderness.

And now, behold thy brothers murmur, saying it is a hard thing which I have required of them; but behold I have not required it of them, but it is a commandment of the Lord.

Therefore go, my son, and thou shalt be favored of the Lord, because thou hast not murmured.

And it came to pass that I, Nephi, said unto my father: I will go and do the things which the Lord hath commanded, for I know that the Lord giveth no commandments unto the children of men, save he shall prepare a way for them that they may accomplish the thing which he commandeth them.

And it came to pass that when my father had heard these words he was exceedingly glad, for he knew that I had been blessed of the Lord.

And I, Nephi, and my brethren took our journey in the wilderness, with our tents, to go up to the land of Jerusalem.

And it came to pass that when we had gone up to the land of Jerusalem, I and my brethren did consult one with another.

And we cast lots—who of us should go in unto the house of Laban. And it came to pass that the lot fell upon Laman; and Laman went in unto the house of Laban, and he talked with him as he sat in his house.

12 Мөнхүү тэрээр миний эцгийн угийн бичгийг агуулсан, гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэрхүү цэдгийг Лебенээс хүссэн ажгуу.

13 Мөн болгоогтун, улиран тохиох дор Лебен уурлаж түүнийг дэргэдээсээ хөөн зайлуулав; мөн тэрээр уг цэдгүүдийг түүнд өгөхийг хүссэнгүй. Иймийн тул, тэрээр түүнд хандан: Болгоогтун, чи бол дээрэмчин, би чамайг хөнөөнө гэв.

14 Гэвч Лемен түүний дэргэдээс зугтан гарч, мөн бидэнд Лебений хэрхсэнийг хэлэв. Мөн бид ихэд харамсаж эхлэн, мөн ах нар маань аглаг буйдад буй эцэгтээ буцахыг завдав.

15 Гэвч болгоогтун, би тэдэнд хандан ийнхүү өгүүлэв: Их Эзэн амьдын адил, мөн бидний амьд нь илэрхийн адил, бид Их Эзэний зарлигласан зүйлийг гүйцэлдүүлэх хүртэл бид аглаг буйдад буй эцэг уруугаа очихоор явахгүй.

16 Иймийн тул, Их Эзэний зарлигийг дагахад итгэлийг хичээе, тиймийн тул эцгийнхээ өвлөж ирсэн газрыг зорьё, учир нь болгоогтун, тэрбээр алт болон мөнгөө бас бүх баялгаа орхисон буюу. Мөн түүний үйлдсэн энэ бүхэн нь Их Эзэний зарлигуудын улмаас болой.

17 Хүмүүсийн ёсон бусын учир, Иерусалим устгагдах ёстойг тэрбээр мэдсэн ажгуу.

18 Учир нь болгоогтун, тэд бошиглогчдын үгсийг эсэргүүцэв. Иймийн тул эцэг минь тэр нутгаас зугтан гар хэмээгдэн зарлиглуулсныхаа дараа уг нутагт үлдсэн бол, болгоогтун, тэр ч бас эрсдэх байсан буйза. Иймийн тул тэрээр эл нутгаас зугтан гарах ёстой болсон ажгуу.

19 Мөн болгоогтун, эцэг өвгөдийн хэлийг үр хүүхдүүддээ хадгалуулан үлдээхийн тулд бид энэхүү цэдгүүдийг олж авах нь Бурханы мэргэн ухаан буюу.

20 Мөн түүнчлэн бид энэ дэлхийн эхлэлээс бүр эдүгээ цагийг хүртэл, бүх ариун бошиглогчдын амаар тэдэнд хэлэгдсэн, Бурханы Сүнс болон хүч чадлаар тэдэнд хүргэгдсэн, тэдгээр үгсийг өвлүүлэн үлдээхийн тулд болой.

21 Мөнхүү улиран тохиох дор Бурханы зарлигийг гүйцээхдээ итгэлтэй байж болохын тул иймэрхүү маягийн хэлээр би ах нараа ятгав.

And he desired of Laban the records which were engraven upon the plates of brass, which contained the genealogy of my father.

And behold, it came to pass that Laban was angry, and thrust him out from his presence; and he would not that he should have the records. Wherefore, he said unto him: Behold thou art a robber, and I will slay thee.

But Laman fled out of his presence, and told the things which Laban had done, unto us. And we began to be exceedingly sorrowful, and my brethren were about to return unto my father in the wilderness.

But behold I said unto them that: As the Lord liveth, and as we live, we will not go down unto our father in the wilderness until we have accomplished the thing which the Lord hath commanded us.

Wherefore, let us be faithful in keeping the commandments of the Lord; therefore let us go down to the land of our father's inheritance, for behold he left gold and silver, and all manner of riches. And all this he hath done because of the commandments of the Lord.

For he knew that Jerusalem must be destroyed, because of the wickedness of the people.

For behold, they have rejected the words of the prophets. Wherefore, if my father should dwell in the land after he hath been commanded to flee out of the land, behold, he would also perish. Wherefore, it must needs be that he flee out of the land.

And behold, it is wisdom in God that we should obtain these records, that we may preserve unto our children the language of our fathers;

And also that we may preserve unto them the words which have been spoken by the mouth of all the holy prophets, which have been delivered unto them by the Spirit and power of God, since the world began, even down unto this present time.

And it came to pass that after this manner of language did I persuade my brethren, that they might be faithful in keeping the commandments of God.

- 22 Мөнхүү улиран тохиох дор бид өвлөж ирсэн нутаг уруугаа очиж, мөн өөрсдийн алт болон мөнгөө мөн үнэт зүйлсээ нэгтгэн цуглуулав.
- 23 Мөн бид эдгээр зүйлсийг цуглуулж авсныхаа дараа, бид Лебений гэрт буцаж очсон болой.
- 24 Мөнхүү улиран тохиох дор бид Лебэнд дахин очиж, мөн уг гуулин ялтсууд дээр сийлэгдсэн цэдгүүдийг бидэнд өгөхийг түүнээс хүсээд, бид үүний төлөө түүнд өөрсдийн алт болон мөнгөө, мөн бүх үнэт зүйлсээ өгье хэмээв.
- 25 Мөнхүү улиран тохиох дор Лебен бидний эдийг, басхүү тэдгээрийн үлэмж агууг үзээд, тэрээр тэдгээрт шунаж, үүний хэрээр биднийг хөөж гарган, мөн тэр өөрөө эдийг маань эзэмдэхийн тулд биднийг хороологохоор зарц нараа илгээв.
- 26 Мөнхүү улиран тохиох дор Лебений зарц нараас зугтан, мөн бид өөрсдийн эдийг ардаа орхихоос аргагүйд хүрсэн буюу, ингээд энэ нь Лебений гарт орох нь тэр.
- 27 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйд тийш зугтаж, тэгээд Лебений зарц нар биднийг эс гүйцэв, мөн бид өөрсдийгөө хадны хөндийд далдлан нуув.
- 28 Мөнхүү улиран тохиох дор Лемен надад, мөн түүнчлэн эцэгт минь уурлав; мөн түүнчлэн Лемүел ч, учир нь тэрээр Лемений үгсийг зөвшөөрөн дагах ажгуу. Иймийн тул Лемен, Лемүел хоёр бидэнд, дүү нартаа олон хатуу үгсийг хэлж, биднийг занчив, бүр саваагаар болой.
- 29 Мөнхүү улиран тохиох дор тэд биднийг саваагаар занчиж ахуйд, болгоогтун, Их Эзэний тэнгэр элч хүрэлцэн ирж тэдний өмнө зогсоод, мөн тэрээр тэдэнд хандаж өгүүлсэн нь: Та нар юуны учир дүүгээ саваагаар занчина? Та нарын алдсын учир Их Эзэн түүнийг та бүгдийн захирагч хэмээн сонгосныг та нар эс мэдэх бил үү? Болгоогтун, та нар Иерусалим өөд дахин одох болно, мөн Их Эзэн Лебенийг та нарын гарт оруулах болно.
- 30 Мөнхүү тэнгэр элч бидэнд ярьсны дараа тэрээр одов.

And it came to pass that we went down to the land of our inheritance, and we did gather together our gold, and our silver, and our precious things.

And after we had gathered these things together, we went up again unto the house of Laban.

And it came to pass that we went in unto Laban, and desired him that he would give unto us the records which were engraven upon the plates of brass, for which we would give unto him our gold, and our silver, and all our precious things.

And it came to pass that when Laban saw our property, and that it was exceedingly great, he did lust after it, insomuch that he thrust us out, and sent his servants to slay us, that he might obtain our property.

And it came to pass that we did flee before the servants of Laban, and we were obliged to leave behind our property, and it fell into the hands of Laban.

And it came to pass that we fled into the wilderness, and the servants of Laban did not overtake us, and we hid ourselves in the cavity of a rock.

And it came to pass that Laman was angry with me, and also with my father; and also was Lemuel, for he hearkened unto the words of Laman. Wherefore Laman and Lemuel did speak many hard words unto us, their younger brothers, and they did smite us even with a rod.

And it came to pass as they smote us with a rod, behold, an angel of the Lord came and stood before them, and he spake unto them, saying: Why do ye smite your younger brother with a rod? Know ye not that the Lord hath chosen him to be a ruler over you, and this because of your iniquities? Behold ye shall go up to Jerusalem again, and the Lord will deliver Laban into your hands.

And after the angel had spoken unto us, he departed.

31 Мөн эл тэнгэр элч одсоны дараа, Лемен, Лемүел дахин бувтналдаж эхлэв, өгүүллрүүн: Их Эзэн Лебенийг бидний гарт оруулна гэдэг яахан боломжтой байх билээ? Болгоогтун, тэр чадалтай хүн, мөн тэр тавьд тушаал буулгаж чадах, тийм ээ, түүгээр ч үл барам тавийг хөнөөж чадах нэгэн; тэгвэл биднийг ч бас тэгэхгүй гэж үү

And after the angel had departed, Laman and Lemuel again began to murmur, saying: How is it possible that the Lord will deliver Laban into our hands? Behold, he is a mighty man, and he can command fifty, yea, even he can slay fifty; then why not us?

## I Нифай 4

- 1 Мөнхүү улиран тохиох дор би ах нартаа хандаж, буцацгаая, мөн Их Эзэний зарлигуудыг сахихдаа итгэлтэй байцгаая; учир нь болгоогтун тэрээр бүхий л дэлхийнхээс илүү чадалтай атал яахан Лебен болон түүний тавь, тийм ээ, эсвэл бүр түүний хэдэн арван мянгаас илүү чадалтай биш байх билээ
- 2 Тиймийн тул бүгдээрээ өгсөн явцгаая; Мосегийн адил хүчтэй байцгаая; учир нь тэрбээр үнэнээр Улаан тэнгисийн усанд хандан ярьсан бөгөөд тэр нь нааш цааш хуваагдан, ингээд бидний эцэг өвгөд дарангуйллаас ангижирч, хуурай газар дээгүүр хөндлөн гарч харин Фараоны их цэрэг дагаж орсон хэдий ч Улаан тэнгисийн усанд үйж үрэгдсэн буюу.
- 3 Эдүгээ болгоогтун энэ нь үнэнийг та нар мэднэ; мөн түүнчлэн тэнгэр элч та нарт хандан ярьсаныг та нар мэднэ; иймийн тул та нар эргэлзэж яахан чадна? Бүгдээрээ явцгаая; Их Эзэн биднийг бүр эцэг өвгөдийг минь чөлөөлсний адилаар чөлөөлж, бүр египетчүүдийг устгасны нэгэн адил, Лебенийг устгах чадалтай бөлгөө.
- 4 Эдүгээ намайг эдгээр үгсийг ярьсны дараа, тэд бас хилэгнэсээр, мөн үргэлжлэн бувтналдсаар байв; гэсэн хэдий ч Иерусалимын хэрмийн гадна иртэл тэд намайг дагасан буюу.
- 5 Мөнхүү энэ нь шөнөөр тохиов; мөн би тэднийг хэрмийн гадна өөрсдийгөө далдлан нуух болгов. Мөн тэднийг нуугдсаны дараа, би, Нифай, хотод сэм гэтэж ороод, Лебений гэрийг чиглэн явав.
- 6 Мөн би хийвэл зохих зүйлүүдийг урьдаас мэдэхгүй байсны учир бибээр Сүнсэнд хөглөгдөн байлаа.
- 7 Гэсэн хэдий ч би урагшлан явж, мөн бибээр Лебений гэрт дөхөж ирэх үедээ би нэгэн хүнийг ажиглав, мөн тэрээр дарсанд согтсоны учир миний өмнө газар унасан байв.
- 8 Мөн би түүн рүү хүрч очоод энэ нь Лебен байсныг олж мэдсэн бөлгөө.
- 9 Мөнхүү бибээр түүний илдийг ажин, би тэрнийг хуйнаас нь сугалав; мөн бариул нь шижир алт, бас ур хийц нь үлэмж сайн, бас ир нь хамгийн үнэт болд байхыг харсан буюу.

## I Nephi 4

And it came to pass that I spake unto my brethren, saying: Let us go up again unto Jerusalem, and let us be faithful in keeping the commandments of the Lord; for behold he is mightier than all the earth, then why not mightier than Laban and his fifty, yea, or even than his tens of thousands?

Therefore let us go up; let us be strong like unto Moses; for he truly spake unto the waters of the Red Sea and they divided hither and thither, and our fathers came through, out of captivity, on dry ground, and the armies of Pharaoh did follow and were drowned in the waters of the Red Sea.

Now behold ye know that this is true; and ye also know that an angel hath spoken unto you; wherefore can ye doubt? Let us go up; the Lord is able to deliver us, even as our fathers, and to destroy Laban, even as the Egyptians.

Now when I had spoken these words, they were yet wroth, and did still continue to murmur; nevertheless they did follow me up until we came without the walls of Jerusalem.

And it was by night; and I caused that they should hide themselves without the walls. And after they had hid themselves, I, Nephi, crept into the city and went forth towards the house of Laban.

And I was led by the Spirit, not knowing beforehand the things which I should do.

Nevertheless I went forth, and as I came near unto the house of Laban I beheld a man, and he had fallen to the earth before me, for he was drunken with wine.

And when I came to him I found that it was Laban.

And I beheld his sword, and I drew it forth from the sheath thereof; and the hilt thereof was of pure gold, and the workmanship thereof was exceedingly fine, and I saw that the blade thereof was of the most precious steel.

- 10 Мөнхүү улиран тохиох дор бибээр Лебенийг албал зохино хэмээн Сүнсээр албадуулав; гэвч би зүрх сэтгэлдээ хэлрүүн: Хэзээ ч ямар ч цагт би хүний цус урсгасан нь үгүй. Бас би зайлсхийн мөн түүнийг устгахгүй байж болох биш үү хэмээв.
- 11 Мөн Сүнс дахин надад хандаж: Болгоогтун, Их Эзэн түүнийг чиний гарт оруулсан болой хэмээв. Тийм ээ, мөн тэрээр миний амийг авахаар эрэлхийлснийг би мэдсэн билээ; тийм ээ, тэр Их Эзэний зарлигуудыг дуулахгүй байв; мөн тэр бидний эд хөрөнгийг салган авсан билээ.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Сүнс надад дахин хандан: Их Эзэн түүнийг чиний гарт оруулсан учир түүнийг устга хэмээв.
- 13 Их Эзэн зөв шударга зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд ёсон бус тэднийг хөнөөдгийг болгоогтун. Нэгэн үндэстэн бууран доройтож мөн итгэлгүйдээ мөхсөнөөс нэг хүн эрсэдсэн нь дээр буюу.
- 14 Мөн эдүгээ, Нифай, би эдгээр үгсийг сонссоны дараа, Их Эзэн надад хандан: Чиний үр сад миний зарлигийг дагахын хэрээр тэд амлалтын нутагт дэгжих болно хэмээн аглаг буйдад ярьсан үгсийг саналаа.
- 15 Тийм ээ, мөн түүнчлэн тэдэнд Мосегийн хууль байхгүйн улмаас уг хуулийн дагуу тэд Их Эзэний зарлигуудыг дагаж чадахгүйд хүрэх буюу хэмээн би сэтгэв.
- 16 Мөн түүнчлэн би уг хууль гуулин ялтсууд дээр сийлэгдсэнийг мэдсэн бөлгөө.
- 17 Мөн үүнчлэн түүний зарлигуудын дагуу би цэдгүүдийг олж авч болохын учир—энэ шалтгааны улмаас Их Эзэн, Лебенийг миний гарт өгснийг мэдсэн буюу.
- 18 Тиймийн тул би Сүнсний дуу хоолойг дагаж Лебений толгойн үснээс татан, өөрийнх нь илдээр би түүний толгойг тас цавчив.
- 19 Мөнхүү би түүний толгойг өөрийнх нь илдээр цавчсаны дараа, би Лебений хувцсыг авч, өөрийн биед өмсөв; тийм ээ, бүр нэг бүрчлэн; мөн би түүний хуягийг авч биедээ агсав.

And it came to pass that I was constrained by the Spirit that I should kill Laban; but I said in my heart: Never at any time have I shed the blood of man. And I shrunk and would that I might not slay him.

And the Spirit said unto me again: Behold the Lord hath delivered him into thy hands. Yea, and I also knew that he had sought to take away mine own life; yea, and he would not hearken unto the commandments of the Lord; and he also had taken away our property.

And it came to pass that the Spirit said unto me again: Slay him, for the Lord hath delivered him into thy hands;

Behold the Lord slayeth the wicked to bring forth his righteous purposes. It is better that one man should perish than that a nation should dwindle and perish in unbelief.

And now, when I, Nephi, had heard these words, I remembered the words of the Lord which he spake unto me in the wilderness, saying that: Inasmuch as thy seed shall keep my commandments, they shall prosper in the land of promise.

Yea, and I also thought that they could not keep the commandments of the Lord according to the law of Moses, save they should have the law.

And I also knew that the law was engraven upon the plates of brass.

And again, I knew that the Lord had delivered Laban into my hands for this cause—that I might obtain the records according to his commandments.

Therefore I did obey the voice of the Spirit, and took Laban by the hair of the head, and I smote off his head with his own sword.

And after I had smitten off his head with his own sword, I took the garments of Laban and put them upon mine own body; yea, even every whit; and I did gird on his armor about my loins.



20 Мөн би үүнийг хийсний дараа, би Лебений сан хөмрөгийг чиглэн явлаа. Тийнхүү би Лебений сангийн зүг явж байхдаа, болгоогтун, Лебений зарц, сангийн түлхүүрийг баригч түүнийг би харав. Мөн би түүнд Лебений дуугаар, түүнийг надтай хамт санд очвол зохино хэмээн тушаалаа.

21 Мөн тэр миний хувцас болон түүнчлэн хэвлийн тус бүсэлсэн илдийг харсан учир тэрбээр намайг өөрийн эзэн Лебен хэмээн бодсон байв.

22 Мөн тэрээр надад хандан иудейчүүдийн ахлагчдын тухай ярьж байв, тэрээр түүний эзэн, Лебен, шөнөөр тэдний дунд байсныг мэдэж байсны учир болой.

23 Мөн би түүнд хандан Лебен байсан мэтээр ярьж байлаа.

24 Мөнхүү түүнчлэн би түүнд хандан би гуулин ялтсууд дээр хийгдсэн тэр сийлбэрийг хэрмийн гадна буй ах нартаа аваачих ёстой хэмээн ярьсан болой.

25 Мөн түүнчлэн намайг дагахыг би түүнд тушаасан буюу.

26 Мөн тэрээр намайг сүм дэх ах нарынхаа тухай ярьж буй бөгөөд намайг үнэхээр миний алсан тэрхүү Лебен хэмээн бодсон буюу, иймийн тул тэрбээр намайг дагасан авай.

27 Мөн тэрбээр надад хандан намайг хэрмийн гадна буй ах нартаа очихоор явах зуур иудейчүүдийн ахлагчдын талаар олон удаа ярьсан бөлгөө.

28 Мөнхүү улиран тохиох дор Лемен намайг хараад машинд айв, мөн Лемүел болон Сам ч бас адил. Мөн тэд миний бараанаар зугтаан одов; учир нь тэд энэ нь Лебен байж мөн тэр намайг алаад бас тэдний амийг авахаар эрэлхийлж буй хэмээн бодсон ажээ.

29 Мөнхүү улиран тохиох дор би тэдний араас дуудав, мөн тэд намайг сонсов; иймийн тул тэд миний дэргэдээс зугтаахаа орхив.

30 Мөнхүү улиран тохиох дор Лебений зарц ах нарыг минь хараад дагжиж эхлэв, мөн тэрээр миний хажуугаас зугтан бас Иерусалим хотод буцахыг завдав.

31 Мөн эдүгээ би, Нифай, бие томтой, түүнчлэн Их Эзэнээс ихээхэн чадлыг авсан тул, тиймийн тул би Лебений зарцыг барин авч, түүнийг зугтаалгахгүйн тул хориглон байсан болой.

And after I had done this, I went forth unto the treasury of Laban. And as I went forth towards the treasury of Laban, behold, I saw the servant of Laban who had the keys of the treasury. And I commanded him in the voice of Laban, that he should go with me into the treasury.

And he supposed me to be his master, Laban, for he beheld the garments and also the sword girded about my loins.

And he spake unto me concerning the elders of the Jews, he knowing that his master, Laban, had been out by night among them.

And I spake unto him as if it had been Laban.

And I also spake unto him that I should carry the engravings, which were upon the plates of brass, to my elder brethren, who were without the walls.

And I also bade him that he should follow me.

And he, supposing that I spake of the brethren of the church, and that I was truly that Laban whom I had slain, wherefore he did follow me.

And he spake unto me many times concerning the elders of the Jews, as I went forth unto my brethren, who were without the walls.

And it came to pass that when Laman saw me he was exceedingly frightened, and also Lemuel and Sam. And they fled from before my presence; for they supposed it was Laban, and that he had slain me and had sought to take away their lives also.

And it came to pass that I called after them, and they did hear me; wherefore they did cease to flee from my presence.

And it came to pass that when the servant of Laban beheld my brethren he began to tremble, and was about to flee from before me and return to the city of Jerusalem.

And now I, Nephi, being a man large in stature, and also having received much strength of the Lord, therefore I did seize upon the servant of Laban, and held him, that he should not flee.

32 Мөнхүү улиран тохиох дор би түүнд хэрэв тэрээр миний үгийг сонсоос, Их Эзэн амьдын адил мөн би ч амьд буйн адилаар, тэрчлэн хэрэв тэрээр бидний үгсийг дуулбал, бид түүний амийг өршөөнө хэмээн өгүүлэв.

33 Ингээд би түүнд хандан, түүнийг айх хэрэггүй хэмээн бүр ам алдав; хэрэв тэр бидэнтэй хамт аглаг буйд уруу явбал бидний адил чөлөөт хүн болно хэмээн хэлэв.

34 Мөн түүнчлэн би түүнд хандаж хэлрүүн: Их Эзэн энэ зүйлийг хийлгэхээр бидэнд зарлигласан нь дамжиггүй; мөн бид Их Эзэний зарлигуудыг биелүүлэхээр чармайх ёсгүй гэж үү? Тиймийн тул, хэрэв та аглаг буйд тийш, эцэгт минь очвол бидний дунд орших байр танд байх болно.

35 Мөн улиран тохиох дор Зорам миний ярьсан үгэнд зоригжив. Эдүгээ Зорам гэдэг нь уг зарцын нэр ажгуу; мөн тэрээр аглаг буйд тийш одож бидний эцэгт очно хэмээн амлав. Тийм ээ, мөн түүнчлэн тэр цагаас эхлэн бидэнтэй үлдэнэ хэмээн тэр бидэнд тангараг тавив.

36 Эдүгээ бид түүнийг өөрсөдтэйгөө хамт үлдээхийг хүссэн нь иудейчүүд аглаг буйд тийш бидний дүрвэснийг мэдэхгүй байж магад, тэд биднийг мөшгөж мөн биднийг устгах болуузай хэмээсний учир бөлгөө.

37 Мөнхүү улиран тохиох дор Зорамыг бидэнд тангараг тавихад, түүний талаарх бидний айдас замрав.

38 Мөнхүү улиран тохиох дор бид гуулин ялтсуудыг бас Лебений зарцыг авч, аглаг буйд тийш одож, эцгийн майхны зүг аяны мөр хөөв.

And it came to pass that I spake with him, that if he would hearken unto my words, as the Lord liveth, and as I live, even so that if he would hearken unto our words, we would spare his life.

And I spake unto him, even with an oath, that he need not fear; that he should be a free man like unto us if he would go down in the wilderness with us.

And I also spake unto him, saying: Surely the Lord hath commanded us to do this thing; and shall we not be diligent in keeping the commandments of the Lord? Therefore, if thou wilt go down into the wilderness to my father thou shalt have place with us.

And it came to pass that Zoram did take courage at the words which I spake. Now Zoram was the name of the servant; and he promised that he would go down into the wilderness unto our father. Yea, and he also made an oath unto us that he would tarry with us from that time forth.

Now we were desirous that he should tarry with us for this cause, that the Jews might not know concerning our flight into the wilderness, lest they should pursue us and destroy us.

And it came to pass that when Zoram had made an oath unto us, our fears did cease concerning him.

And it came to pass that we took the plates of brass and the servant of Laban, and departed into the wilderness, and journeyed unto the tent of our father.

## I Нифай 5

- 1 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйдад эцэгтээ ирсний дараа, болгоогтун, тэрбээр баяр хөөрөөр дүүргэгдсэн байв, мөн түүнчлэн миний эх Сариа, үлэмж хангалуун байв, учир нь тэрээр бидний төлөө үнэхээр гашуудан байсан ажгуу.
- 2 Учир нь тэр биднийг аглаг буйдад үрэгдсэн хэмээн бодсон ажээ; мөн тэрээр эцгийн минь эсрэг үглэн гомдоллож, тэр зөнч хүн байсныг нь түүнд дурдан; хэлсэн нь: Болгоогтун та биднийг өвлөж ирсэн нутгаас минь дагуулан гаргасан буюу, ингээд хөвгүүд минь үгүй болов, мөн бид аглаг буйдад үрэгдэх буюу.
- 3 Мөн эх минь эцгийн минь эсрэг үглэн иймэрхүү маягийн хэлээр гомдоллосон байв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь түүнд хандаж, хэлсэн нь: Би зөнч хүн гэдгээ мэднэ; хэрэв би Бурханы зүйлүүдийг үзэгдэлд хараагүйсэн бол би Бурханы сайн сайхныг мэдэхгүй байх байсан, харин Иерусалимд хоргодон, ах дүүстэйгээ хамт хөнөөгдөх байсан биз ээ.
- 5 Гэвч болгоогтун, би амлалтын нутгийг олж авлаа, үүн дээр би, эдгээр зүйлүүдэд баясна; тийм ээ, мөн Их Эзэн хөвгүүдийг минь Лебений савраас зайлуулна, мөн тэднийг аглаг буйдад бидэнд дахин авчирна гэдгийг би мэднэ.
- 6 Мөн иймэрхүү маягийн хэлээр миний эцэг Лихай, эх Сариаг бидний тухайд тайтгаруулан байв, биднийг иудейчүүдийн цэдгийг олж авахаар, Иерусалимын газар өөд аглаг буйдад аялах зуур болой.
- 7 Мөн биднийг эцгийнхээ майханд эргэж ирэхэд, болгоогтун тэдний баяр хөөр дүүрч, мөн эх минь тайтгаруулагдав.
- 8 Мөн тэрээр ярьж, хэлсэн нь: Эдүгээ Их Эзэн миний эр нөхөрт аглаг буйд тийш зугтаа хэмээн зарлигласныг би баттай мэдэв; тийм ээ, мөн түүнчлэн Их Эзэн хөвгүүдийг минь хамгаалж, бас Лебений савраас зайлуулсныг мөн Их Эзэн тэдэнд зарлигласан зүйлийг гүйцэлдүүлж чадах хүчийг тэдэнд өгснийг би баттай мэдэв. Мөн тэрээр иймэрхүү маягийн хэлээр ярив.

## I Nephi 5

And it came to pass that after we had come down into the wilderness unto our father, behold, he was filled with joy, and also my mother, Sariah, was exceedingly glad, for she truly had mourned because of us.

For she had supposed that we had perished in the wilderness; and she also had complained against my father, telling him that he was a visionary man; saying: Behold thou hast led us forth from the land of our inheritance, and my sons are no more, and we perish in the wilderness.

And after this manner of language had my mother complained against my father.

And it had come to pass that my father spake unto her, saying: I know that I am a visionary man; for if I had not seen the things of God in a vision I should not have known the goodness of God, but had tarried at Jerusalem, and had perished with my brethren.

But behold, I have obtained a land of promise, in the which things I do rejoice; yea, and I know that the Lord will deliver my sons out of the hands of Laban, and bring them down again unto us in the wilderness.

And after this manner of language did my father, Lehi, comfort my mother, Sariah, concerning us, while we journeyed in the wilderness up to the land of Jerusalem, to obtain the record of the Jews.

And when we had returned to the tent of my father, behold their joy was full, and my mother was comforted.

And she spake, saying: Now I know of a surety that the Lord hath commanded my husband to flee into the wilderness; yea, and I also know of a surety that the Lord hath protected my sons, and delivered them out of the hands of Laban, and given them power whereby they could accomplish the thing which the Lord hath commanded them. And after this manner of language did she speak.

- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд үлэмж ихээр баясан, тэгээд Их Эзэнд тахил өргөж мөн өргөл хайлав; мөн тэд Израилын Бурханд талархлаа дэвшүүлсэн болой.
- 10 Мөн тэд Израилын Бурханд хандан талархлаа дэвшүүлсний эцэст, миний эцэг, Лихай, гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэрхүү цэдгийг авч, мөн тэрбээр тэдгээрийг эхнээс нь судалсан авай.
- 11 Мөн тэрээр тэдгээрт дэлхийн үүслийн, мөн түүнчлэн бидний анхны эцэг эх болсон Адам Ева хоёрын тухай шастирыг багтаасан Мосегийн таван ном агуулагдсаныг болгоов.
- 12 Мөн түүнчлэн эхлэлээс бүр Иудейн хаан, Зедикаягийн засаглалын эхлэл хүртэлх иудейчүүдийн цэдгийг буюу.
- 13 Мөн түүнчлэн ариун бошиглогчдын бошиглолууд нь эхлэлээс, бүр Зедикаягийн хаанчлалын үүслийг хүртэл; мөн түүнчлэн Иеремиагийн амаар яригдсан олон бошиглолыг бөлгөө.
- 14 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг Лихай түүнчлэн гуулин ялтсууд дээрээс эцэг өвгөдийнхөө угийн бичгийг олов; иймийн тул тэрээр Иосефын удам байсныг мэдсэн ажээ; тийм ээ, бүр Иаковын хүү асан тэр, Египетэд худалдагдсан тэр, мөн өөрийн эцэг Иаков, түүний бүхэл өрх гэрийг өлсгөлөнгийн аюулаас хамгаалж болно хэмээн Их Эзэний мутраар хадгалагдан хамгаалагдсан тэрхүү Иосеф болой.
- 15 Мөн түүнчлэн тэднийг хамгаалсан мөнхүү тэр Бурханаар удирдагдан тэд Египет нутгаас мөн дарангуйллаас гарсан бөлгөө.
- 16 Мөнхүү тийн миний эцэг, Лихай, эцэг өвгөдийнхөө уг удмыг мэдэж авсан ажгуу. Мөн түүнчлэн Лебен ч бас Иосефын удам байж, иймийн тул тэр мөн өөрийн эцэг өвгөдийн цэдгийг хадгалж байжээ.
- 17 Мөн эдүгээ эцэг минь эдгээр бүх зүйлийг хараад, тэрээр Сүнсээр дүүргэгдэв, мөн үр удмынхаа тухай бошиглож эхлэв—
- 18 Эдгээр гуулин ялтсууд түүний үр удам болох бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст очно гэдгийг болой.

And it came to pass that they did rejoice exceedingly, and did offer sacrifice and burnt offerings unto the Lord; and they gave thanks unto the God of Israel.

And after they had given thanks unto the God of Israel, my father, Lehi, took the records which were engraven upon the plates of brass, and he did search them from the beginning.

And he beheld that they did contain the five books of Moses, which gave an account of the creation of the world, and also of Adam and Eve, who were our first parents;

And also a record of the Jews from the beginning, even down to the commencement of the reign of Zedekiah, king of Judah;

And also the prophecies of the holy prophets, from the beginning, even down to the commencement of the reign of Zedekiah; and also many prophecies which have been spoken by the mouth of Jeremiah.

And it came to pass that my father, Lehi, also found upon the plates of brass a genealogy of his fathers; wherefore he knew that he was a descendant of Joseph; yea, even that Joseph who was the son of Jacob, who was sold into Egypt, and who was preserved by the hand of the Lord, that he might preserve his father, Jacob, and all his household from perishing with famine.

And they were also led out of captivity and out of the land of Egypt, by that same God who had preserved them.

And thus my father, Lehi, did discover the genealogy of his fathers. And Laban also was a descendant of Joseph, wherefore he and his fathers had kept the records.

And now when my father saw all these things, he was filled with the Spirit, and began to prophesy concerning his seed—

That these plates of brass should go forth unto all nations, kindreds, tongues, and people who were of his seed.

- 19 Иймийн тул, эдгээр гуулин ялтсууд хэзээ ч үрэгдэх учиргүй; цагийг даган бүдгэрэх нь ч бас үгүй хэмээн тэр хэлэв. Мөн тэрээр үр удмынхаа тухай олон зүйлийг бошиглов.
- 20 Мөнхүү улиран тохиох дор өдий хүртэл бидэнд зарлигласан Их Эзэний зарлигуудыг миний эцэг гүйцэлдүүлсэн болой.
- 21 Мөн бид Их Эзэн бидэнд зарлигласнаар цэдгүүдийг олж, мөн тэдгээрийг судалж мөн тэдгээр нь хүсүүштэй болохыг олж мэдэв; тийм ээ, бүр үр хүүхдүүддээ Их Эзэний зарлигуудыг сахиулан өвлүүлэхүйц агуу эрхэм чухал ажгуу.
- 22 Иймийн тул амлалтын нутгийг зорин аглаг буйдад зорчихдоо, бид эдгээрийг өөрсөдтэйгөө авч явах нь Их Эзэний мэргэн ухаан буйза.

Wherefore, he said that these plates of brass should never perish; neither should they be dimmed any more by time. And he prophesied many things concerning his seed.

And it came to pass that thus far I and my father had kept the commandments wherewith the Lord had commanded us.

And we had obtained the records which the Lord had commanded us, and searched them and found that they were desirable; yea, even of great worth unto us, inasmuch that we could preserve the commandments of the Lord unto our children.

Wherefore, it was wisdom in the Lord that we should carry them with us, as we journeyed in the wilderness towards the land of promise.

## 1 Нифай 6

- 1 Мөн эдүгээ би, Нифай, цэдгийнхээ энэ хэсэгт эцэг өвгөдийнхөө угийн бичгийг хожим нэгэн цагт би өөрийн бичиглэн буй эдгээр ялтсууд дээр буулгах нь ч үгүй; энэ нь миний эцгийн хадгалж байсан тэрхүү цэдэгт буйн учир болой; иймийн тул би энэ дэвтэрт үүнийг бичиглэхгүй бөлгөө.
- 2 Тухайлбал бид Иосефын удам гэдгийг хэлэх нь миний хувьд хангалттай.
- 3 Мөн бибээр эцгийнхээ бүхий л зүйлийг бүрэн тодорхой тэмдэглэхийг чухалчилсангүй, учир нь, тэдгээр нь эдгээр ялтсууд дээр бичигдэж чадахгүй, учир нь, би Бурханы зүйлүүдийн тухай бичиж болох тийм зайг би хүсч байна.
- 4 Учир нь, миний бүхий л зорилго бол Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханд ирж, аврагд хэмээн хүмүүнд ятгах нь болой.
- 5 Иймийн тул, би дэлхийд таалагдах зүйлүүдийг бус, харин Бурханы таалалд мөн дэлхийд үл харьяалагдах тэдний таалалд нийцэх зүйлүүдийг бичиглэх болой.
- 6 Иймийн тул, хүмүүний үрст эрхэм чухал бус зүйлүүдээр эдгээр ялтсуудыг дүүргэх ёсгүй хэмээн би үр удамдаа зарлиглах болно.

## 1 Nephi 6

And now I, Nephi, do not give the genealogy of my fathers in this part of my record; neither at any time shall I give it after upon these plates which I am writing; for it is given in the record which has been kept by my father; wherefore, I do not write it in this work.

For it sufficeth me to say that we are descendants of Joseph.

And it mattereth not to me that I am particular to give a full account of all the things of my father, for they cannot be written upon these plates, for I desire the room that I may write of the things of God.

For the fulness of mine intent is that I may persuade men to come unto the God of Abraham, and the God of Isaac, and the God of Jacob, and be saved.

Wherefore, the things which are pleasing unto the world I do not write, but the things which are pleasing unto God and unto those who are not of the world.

Wherefore, I shall give commandment unto my seed, that they shall not occupy these plates with things which are not of worth unto the children of men.

## 1 Нифай 7

- 1 Мөн эдүгээ, миний эцэг, Лихай, үр удмынхаа талаар бошиглогсны дараа, мөнхүү улиран тохиох дор Их Эзэн түүнд хандан дахин ярьж, Лихай, зөвхөн өөрийн гэр бүлийг авч аглаг буйд тийш зорчих нь зохистой биш болой; харин тэр амлагдсан нутагт Их Эзэний төлөө үр удмаа өсгөж болохын тулд, хөвгүүд чинь охидыг эхнэр болгон авбал зохилтойг та нар мэдээсэй хэмээнэ би.
- 2 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай түүнчлэн миний ах нар Иерусалим газарт дахин буцаж, тэгээд Ишмәил болон түүний гэр бүлийг аглаг буйдад авчирвал зохилтой хэмээн Их Эзэн түүнд зарлигласан болой.
- 3 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, ах нарынхаа хамт Иерусалим өөд зорин аглаг буйд тийш дахин зорчив.
- 4 Мөнхүү улиран тохиох дор бид Ишмәилийн гэрт хүрч очоод, бид Ишмәилийн зүгээс тааллыг олж, үүнийхээ хэрээр түүнд хандан Их Эзэний үгсийг ярьсан ажгуу.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Ишмәилийн зүрхийг зөөллөсөн буюу, мөн түүнчлэн түүний гэрийнхнийх нь ч, үүний дүнд тэд бидэнтэй хамт эцгийн маань майхан уруу зорин аглаг буйдад аянд гарваа.
- 6 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйдад зорчих зуур, болгоогтун, Лемен болон Лемүел, мөн Ишмәилийн охидоос хоёр нь, мөн Ишмәилийн хоёр хүү болон тэдний гэр бүлийнхэн, биднийг эсэргүүцэв; тийм ээ, Нифай миний эсрэг болон Сам, мөн тэдний эцэг Ишмәил, мөн түүний эхнэр, мөн түүний бусад гурван охины эсрэг бөлгөө.
- 7 Мөнхүү улиран тохиох дор уг эсэргүүцэл нь тэд Иерусалимын нутагт буцахыг хүссэнээс болой.
- 8 Мөн эдүгээ би, Нифай, тэдний зүрх сэтгэл хатуугийн учир харамсан байв, тиймийн тул би тэдэнд хандан ярьж, хэлрүүн, тийм ээ, бүр Леменд мөн Лемүелд хандан: Болгоогтун, та нар миний ах нар, тэгээд та нар яахан зүрх сэтгэлээрээ ийм хатуу, мөн оюун тань ийм харалган билээ, тиймээс ч би, та нарын дүү атал, та нарт хандан ярих ёстой болж, тийм ээ, мөн та нарт үлгэрлэх хэрэг үү

## 1 Nephi 7

And now I would that ye might know, that after my father, Lehi, had made an end of prophesying concerning his seed, it came to pass that the Lord spake unto him again, saying that it was not meet for him, Lehi, that he should take his family into the wilderness alone; but that his sons should take daughters to wife, that they might raise up seed unto the Lord in the land of promise.

And it came to pass that the Lord commanded him that I, Nephi, and my brethren, should again return unto the land of Jerusalem, and bring down Ishmael and his family into the wilderness.

And it came to pass that I, Nephi, did again, with my brethren, go forth into the wilderness to go up to Jerusalem.

And it came to pass that we went up unto the house of Ishmael, and we did gain favor in the sight of Ishmael, insomuch that we did speak unto him the words of the Lord.

And it came to pass that the Lord did soften the heart of Ishmael, and also his household, insomuch that they took their journey with us down into the wilderness to the tent of our father.

And it came to pass that as we journeyed in the wilderness, behold Laman and Lemuel, and two of the daughters of Ishmael, and the two sons of Ishmael and their families, did rebel against us; yea, against me, Nephi, and Sam, and their father, Ishmael, and his wife, and his three other daughters.

And it came to pass in the which rebellion, they were desirous to return unto the land of Jerusalem.

And now I, Nephi, being grieved for the hardness of their hearts, therefore I spake unto them, saying, yea, even unto Laman and unto Lemuel: Behold ye are mine elder brethren, and how is it that ye are so hard in your hearts, and so blind in your minds, that ye have need that I, your younger brother, should speak unto you, yea, and set an example for you?

- 9 Та нар Их Эзэний үгийг яахан эс дуулав
- 10 Та нар Их Эзэний тэнгэр элчийг харснаа яахан мартсан билээ
- 11 Тийм ээ мөн Их Эзэн биднийг Лебений савраас чөлөөлж, мөн түүнчлэн бид цэдгийг авах болсон зэрэг бидний тул хийсэн үлэмж агуу зүйлүүдийг та нар яахан мартаж болов
- 12 Тийм ээ, мөн хэрэв тэд тийнхүү байж итгэлээ бодитой болговол бүх зүйлийг Их Эзэн хүмүүний үрсийн төлөө өөрийн ёсоор болгож болно гэдгийг та нар яахан мартаж болов? Иймийн тул түүнд итгэлтэй байцгаая.
- 13 Мөн хэрэв бид ийнхүү байж түүнд итгэлтэй байвал, бид амлалтын нутагт хүрэх болно; мөн та нар ирээдүйн нэгэн үед Иерусалимын устгалын тухай Их Эзэний үг гүйцэлдэхийг мэдэх болно; учир нь Иерусалимын устгалын талаар Их Эзэний ярьсан тэр бүх зүйл биелэгдэх ёстой.
- 14 Учир нь болгоогтун, Их Эзэний Сүнс тэдний төлөө хичээхээ удахгүй болино; учир нь болгоогтун, тэд бошиглогчдыг эсэргүүцэж, мөн Иеремиаг гянданд хаясан болой. Мөн тэд эцгийн минь амийг авахаар эрэлхийлж, үүний хэрээр түүнийг нутгаасаа зугтан гарахад хүргэсэн буюу.
- 15 Эдүгээ болгоогтун, хэрэв та нар Иерусалим уруу буцвал та нар ч бас тэдэнтэй хамт хөнөөгдөх болно хэмээн би та нарт хэлж байна. Мөн эдүгээ, хэрэв та нар сонгосон бол, тэр газар өөд яв, тэгээд хэрэв та нар явбаас та нар ч түүнчлэн хөнөөгдөнө хэмээн та нарт миний ярьсан үгсийг санагтун; эдгээр нь Их Эзэний Сүнс ярих ёстой хэмээн намайг албадаж байгаагаас буюу.
- 16 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эдгээр үгсийг ах нартаа хандан ярьсны дараа, тэд надад уурлаж байв. Мөнхүү улиран тохиох дор тэд надад гар хүрэв, учир нь болгоогтун, тэд үлэмж ихээр хилэгнэн, мөн тэд намайг олсоор хүлэв, тэд намайг зэрлэг араатанд тасчуулахаар аглаг буйдад орхиж болно хэмээн амийг минь бүрэлгэхээр эрэлхийлсний учир болой.

How is it that ye have not hearkened unto the word of the Lord?

How is it that ye have forgotten that ye have seen an angel of the Lord?

Yea, and how is it that ye have forgotten what great things the Lord hath done for us, in delivering us out of the hands of Laban, and also that we should obtain the record?

Yea, and how is it that ye have forgotten that the Lord is able to do all things according to his will, for the children of men, if it so be that they exercise faith in him? Wherefore, let us be faithful to him.

And if it so be that we are faithful to him, we shall obtain the land of promise; and ye shall know at some future period that the word of the Lord shall be fulfilled concerning the destruction of Jerusalem; for all things which the Lord hath spoken concerning the destruction of Jerusalem must be fulfilled.

For behold, the Spirit of the Lord ceaseth soon to strive with them; for behold, they have rejected the prophets, and Jeremiah have they cast into prison. And they have sought to take away the life of my father, inasmuch that they have driven him out of the land.

Now behold, I say unto you that if ye will return unto Jerusalem ye shall also perish with them. And now, if ye have choice, go up to the land, and remember the words which I speak unto you, that if ye go ye will also perish; for thus the Spirit of the Lord constraineth me that I should speak.

And it came to pass that when I, Nephi, had spoken these words unto my brethren, they were angry with me. And it came to pass that they did lay their hands upon me, for behold, they were exceedingly wroth, and they did bind me with cords, for they sought to take away my life, that they might leave me in the wilderness to be devoured by wild beasts.



17 Гэвч улиран тохиох дор би Их Эзэнд залбирч, хэлсэн нь: Ай Их Эзэн танд итгэх миний итгэлийн улмаас, та намайг ах нарын минь гараас зайлуулаач; тийм ээ, намайг хүлсэн энэ хүлээсийг тасар татах хүчийг өгөөч надад.

18 Мөнхүү улиран тохиох дор намайг эдгээр үгсийг хэлмэгц, болгоогтун, хүлээс гар болон хөлөөс минь алдуурав, мөн би ах нарынхаа өмнө зогсож, бас тэдэнд хандан дахин ярив.

19 Мөнхүү улиран тохиох дор тэд дахин надад уурлаж, мөн надад гар хүрэхийг завдав; гэвч болгоогтун, Ишмэилийн охидоос нэг нь, тийм ээ, мөн түүнчлэн түүний эх, мөн Ишмэилийн хөвгүүдийн нэг нь, ах нараас маань хичээнгүйлэн гуйхын хэрээр тэдний зүрхийг зөөллөв; мөн тэд амийг минь авахаар оролдохоо болив.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн ёсон бусын улмаас харамсан байв, үүний хэрээр тэд миний өмнө бөхийж, мөн миний эсрэг үйлдсэн зүйлийг өршөөхийг тэд надаас гуйв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэдний хийсэн бүгдийг би даруй уучилж, мөн тэд Их Эзэн Бурхандаа хандан өршөөлийн тул залбир хэмээн тэднийг би ухуулав. Мөнхүү улиран тохиох дор тэд тийн үйлдэв. Мөн тэд Их Эзэнд залбирсны эцэст бид дахин эцгийнхээ майхны зүг зорин аяндаа гарсан буюу.

22 Мөнхүү улиран тохиох дор бид эцгийнхээ майханд ирэв. Мөн би болон ах нар маань бас Ишмэилийн бүх гэрийнхэн эцгийн маань майхан уруу ирсний дараа, тэд Их Эзэн Бурхандаа талархал дэвшүүлэв; мөн тэд түүнд тахил өргөн мөн өргөл хайлав.

But it came to pass that I prayed unto the Lord, saying: O Lord, according to my faith which is in thee, wilt thou deliver me from the hands of my brethren; yea, even give me strength that I may burst these bands with which I am bound.

And it came to pass that when I had said these words, behold, the bands were loosed from off my hands and feet, and I stood before my brethren, and I spake unto them again.

And it came to pass that they were angry with me again, and sought to lay hands upon me; but behold, one of the daughters of Ishmael, yea, and also her mother, and one of the sons of Ishmael, did plead with my brethren, insomuch that they did soften their hearts; and they did cease striving to take away my life.

And it came to pass that they were sorrowful, because of their wickedness, insomuch that they did bow down before me, and did plead with me that I would forgive them of the thing that they had done against me.

And it came to pass that I did frankly forgive them all that they had done, and I did exhort them that they would pray unto the Lord their God for forgiveness. And it came to pass that they did so. And after they had done praying unto the Lord we did again travel on our journey towards the tent of our father.

And it came to pass that we did come down unto the tent of our father. And after I and my brethren and all the house of Ishmael had come down unto the tent of my father, they did give thanks unto the Lord their God; and they did offer sacrifice and burnt offerings unto him.

## 1 Нифай 8

- 1 Мөнхүү улиран тохиох дор бид бүхий л зүйлийн үрийг төрөл бүрээр, зүйл бүрийн үр тарианы, мөн түүнчлэн зүйл бүрийн жимсний үрийг аль алиныг нь нэгтгэн цуглуулав.
- 2 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь аглаг буйдад саатан байх зуур тэрээр бидэнд хандан ярьж, өгүүлсэн нь: Болгоогтун, би зүүд зүүдлэв; эсвээс, өөрөөр хэлбэл, би үзэгдэл үзэв.
- 3 Мөн болгоогтун, би үзсэн зүйлийнхээ учир, Их Эзэнд баясах шалтгаан надад буй нь Нифай болон түүнчлэн Самын тул бөлгөө; учир нь тэд болон тэдний үр удмаас олон нь аврагдана гэж бодох шалтгаан надад буй.
- 4 Гэвч болгоогтун, Леман, Лемүел хоёр, би та нарын төлөө үлэмж ихээр айна; учир нь болгоогтун, миний ухаарснаар би зүүдэндээ бүрэнхий мөн дүнсгэр аглаг буйдыг харсан болой.
- 5 Мөнхүү улиран тохиох дор би цагаан орхимж өмссөн нэгэн хүмүүнийг харав; мөн тэрбээр ирж бас миний өмнө зогсов.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр надад хандан ярьж, мөн түүнийг дагахыг надад тушаав.
- 7 Мөнхүү улиран тохиох дор би түүнийг дагаад өөрийгөө бүрэнхий мөн дүнсгэр зэлүүдэд байгааг би ажиглав.
- 8 Мөн би харанхуйд олон цагийн турш зорчсоны эцэст би Их Эзэнд хандан түүний эрхэм их нигүүлслийн улмаас намайг нигүүлсэн үзэхийг хүсэн залбирч эхэлсэн буюу.
- 9 Мөнхүү улиран тохиох дор би Их Эзэнд хандан залбирсны эцэст би уудам болоод цэлгэр талбарыг ажиглав.
- 10 Мөнхүү улиран тохиох дор хүртсэн нэгнийг жаргалтай болгох дур булаам жимстэй нэгэн модыг би харсан бөлгөө.
- 11 Мөнхүү улиран тохиох дор би урагшлан түүний жимснээс хүртэв; мөн энэ нь урьд өмнө миний амсаж асан бүхнээс дээгүүр тэргүүн амтат байсныг би болгоосон бөлгөө. Тийм ээ мөн түүний жимс нь цагаан, урьд өмнө миний үзсэн бүхнээс үлэмж цагаан байсныг би болгоов.

## 1 Nephi 8

And it came to pass that we had gathered together all manner of seeds of every kind, both of grain of every kind, and also of the seeds of fruit of every kind.

And it came to pass that while my father tarried in the wilderness he spake unto us, saying: Behold, I have dreamed a dream; or, in other words, I have seen a vision.

And behold, because of the thing which I have seen, I have reason to rejoice in the Lord because of Nephi and also of Sam; for I have reason to suppose that they, and also many of their seed, will be saved.

But behold, Laman and Lemuel, I fear exceedingly because of you; for behold, methought I saw in my dream, a dark and dreary wilderness.

And it came to pass that I saw a man, and he was dressed in a white robe; and he came and stood before me.

And it came to pass that he spake unto me, and bade me follow him.

And it came to pass that as I followed him I beheld myself that I was in a dark and dreary waste.

And after I had traveled for the space of many hours in darkness, I began to pray unto the Lord that he would have mercy on me, according to the multitude of his tender mercies.

And it came to pass after I had prayed unto the Lord I beheld a large and spacious field.

And it came to pass that I beheld a tree, whose fruit was desirable to make one happy.

And it came to pass that I did go forth and partake of the fruit thereof; and I beheld that it was most sweet, above all that I ever before tasted. Yea, and I beheld that the fruit thereof was white, to exceed all the whiteness that I had ever seen.

- 12 Мөн би түүний жимснээс хүртэхийн сацуу энэ нь миний сэтгэлийг үлэмж агуу баяраар дүүргэв; иймийн тул, гэр бүлийнхэн маань үүнээс түүнчлэн хүртээсэй хэмээн би хүсч эхлэв; би энэ нь бүхий л жимснээс дээгүүр дур булаам болохыг бибээр мэдсэний учир буюу.
- 13 Мөн түүнчлэн гэр бүлийнхнээ олж болзошгүй хэмээн би эргэн тойрон хараа бэлчээвээс, нэгэн уст голыг олж харав би; мөн энэ нь жимснээс нь миний хүртсэн тэр модны дэргэдүүр урсах ажгуу.
- 14 Мөн би үүнийг хаанаас эхтэйг нь ажиглан харав; мөн үүний эх нь ялимгүй цаана байхыг үзэв; мөн үүний эхэн дээр та нарын эх Сариа, мөн Сам болон Нифайг харав; мөн тэд хааш одвол зохихыг мэдэхгүй зогсож байсан болой.
- 15 Мөнхүү улиран тохиох дор би тэднийг даллав; мөн түүнчлэн би тэдэнд хандан өндөр дуугаар тэднийг надад ирж, мөн бүхий л жимснээс дээгүүр хүсэл татам тэр жимснээс хүртвэл зохино хэмээн хэлсэн бөлгөө.
- 16 Мөнхүү улиран тохиох дор тэд надад ирж, мөн жимснээс түүнчлэн хүртсэн авай.
- 17 Мөнхүү улиран тохиох дор Лемеен болон Лемүел хоёрыг ирж мөн түүнчлэн жимснээс хүртээсэй хэмээн би хүсэв; иймийн тул, би тэднийг харж магад хэмээн голын эхэн тийш хараа бэлчээв.
- 18 Мөнхүү улиран тохиох дор би тэднийг харав, гэвч тэд надад ирж жимснээс хүртсэн нь үгүй бөлгөө.
- 19 Мөн би төмөр бариулыг харав, мөн энэ нь голын эргийн дагуу сунан үргэлжилсэн бөгөөд дэргэд нь миний зогсох тэр модны зүг удирдсан авай.
- 20 Мөн түүнчлэн уг төмөр бариулыг дагах, бүр миний дэргэд нь зогссон тэр модонд хүргэх давчуу бөгөөд нарийн замыг би харав; мөн түүнчлэн энэ нь урсгалын эхийн дэргэдүүр өнгөрч, дэлхий мэт уужим бөгөөд цэлгэр талбар тийш удирдах ажээ.
- 21 Мөн би тоогүй олон хүмүүсийг харав, дэргэд нь миний зогссон тэр модны зүг удирдах замыг олохоор тэднээс олон нь урагш зүтгэж байгааг би харав.
- 22 Мөнхүү улиран тохиох дор тэд урагшлан мөн модны зүг дагуулах замаар явж эхэлсэн буюу.

And as I partook of the fruit thereof it filled my soul with exceedingly great joy; wherefore, I began to be desirous that my family should partake of it also; for I knew that it was desirable above all other fruit.

And as I cast my eyes round about, that perhaps I might discover my family also, I beheld a river of water; and it ran along, and it was near the tree of which I was partaking the fruit.

And I looked to behold from whence it came; and I saw the head thereof a little way off; and at the head thereof I beheld your mother Sariah, and Sam, and Nephi; and they stood as if they knew not whither they should go.

And it came to pass that I beckoned unto them; and I also did say unto them with a loud voice that they should come unto me, and partake of the fruit, which was desirable above all other fruit.

And it came to pass that they did come unto me and partake of the fruit also.

And it came to pass that I was desirous that Laman and Lemuel should come and partake of the fruit also; wherefore, I cast mine eyes towards the head of the river, that perhaps I might see them.

And it came to pass that I saw them, but they would not come unto me and partake of the fruit.

And I beheld a rod of iron, and it extended along the bank of the river, and led to the tree by which I stood.

And I also beheld a strait and narrow path, which came along by the rod of iron, even to the tree by which I stood; and it also led by the head of the fountain, unto a large and spacious field, as if it had been a world.

And I saw numberless concourses of people, many of whom were pressing forward, that they might obtain the path which led unto the tree by which I stood.

And it came to pass that they did come forth, and commence in the path which led to the tree.

23 Мөнхүү улиран тохиох дор харанхуй манан бий болов; тийм ээ, бүр харанхуй үлэмжийн их манан, үүний хэрээр харгуйг эхэлсэн тэд замаа алдсанаар тэд хэрэн тэнэж төөрөлдөх ажгуу.

24 Мөнхүү улиран тохиох дор шаргуу урагшлан буй бусдыг би ажив, мөн тэд урагшлан мөн төмөр бариулын үзүүрт хүрэн барив; мөн тэд харанхуй манан дундуур зүтгэн урагшилж, ойртон бүр мөн уг модны жимснээс тэд хүртэх хүртлээ төмөр бариулаас барьсаар явах ажээ.

25 Мөн тэд уг модны жимснээс хүртсэний дараа тэд ичингүйрхэв гэлтэй нүд бэлчээн харах ажээ.

26 Мөн түүнчлэн би эргэн тойрон хараа бэлчээн, бас уст голын нөгөө эрэгт агуу хийгээд нүсэр барилгыг харав; мөн энэ нь газраас өндөрт, агаарт тогтсон мэт байв.

27 Мөн энэ нь өтөл болоод залуу, эрэгтэй болоод эмэгтэй хүмүүсээр дүүрэн байв; мөн тэдний хувцасласан маяг нь үлэмж тансаг; мөн тэд, ирж бас жимснээс хүртсэн тэднийг хуруугаараа занган басхүү элгэлэх байдалтай байх ажээ.

28 Мөн тэд жимсийг амссаныхаа дараа тэднийг тохуурхсан тэднээс ичингүйрхсэн болой; мөн тэд хориглогдсон замаар будилан орж мөн төөрч байв.

29 Мөн эдүгээ би, Нифай, эцгийнхээ бүх үгсийг ярих нь үгүй.

30 Гэвч товчлон бичвээс, болгоогтун, замаараа урагш зүтгэж буй бусад олныг тэрээр харав; тэд ирж бас төмөр бариулын үзүүрт хүрч барив; мөн тэд урагшлан, доош унаад мөн уг модны жимснээс хүртэх хүртэл төмөр бариулаас үргэлж тууштай зуурсаар урагш зүтгэх бөлгөө.

31 Мөн түүнчлэн тэрбээр агуу хийгээд нүсэр барилгыг зүглэн бэдрэх бусад олныг харсан бөлгөө.

32 Мөнхүү улиран тохиох дор олон нь урсгалын гүнд живэв; мөн олон нь түүний хараанаас алдран, этгээд замаар бэдрэх бөлгөө.

33 Мөн уг этгээд барилга уруу орогсод үлэмж олон байв. Мөн тэд тэр барилга дотор орсны эцэст түүнчлэн жимснээс хүртэх намайг болон тэднийг хуруугаараа занган тохуурхацгаах аж; гэвч бид тэднийг анхаарсан нь үгүй болой.

And it came to pass that there arose a mist of darkness; yea, even an exceedingly great mist of darkness, inasmuch that they who had commenced in the path did lose their way, that they wandered off and were lost.

And it came to pass that I beheld others pressing forward, and they came forth and caught hold of the end of the rod of iron; and they did press forward through the mist of darkness, clinging to the rod of iron, even until they did come forth and partake of the fruit of the tree.

And after they had partaken of the fruit of the tree they did cast their eyes about as if they were ashamed.

And I also cast my eyes round about, and beheld, on the other side of the river of water, a great and spacious building; and it stood as it were in the air, high above the earth.

And it was filled with people, both old and young, both male and female; and their manner of dress was exceedingly fine; and they were in the attitude of mocking and pointing their fingers towards those who had come at and were partaking of the fruit.

And after they had tasted of the fruit they were ashamed, because of those that were scoffing at them; and they fell away into forbidden paths and were lost.

And now I, Nephi, do not speak all the words of my father.

But, to be short in writing, behold, he saw other multitudes pressing forward; and they came and caught hold of the end of the rod of iron; and they did press their way forward, continually holding fast to the rod of iron, until they came forth and fell down and partook of the fruit of the tree.

And he also saw other multitudes feeling their way towards that great and spacious building.

And it came to pass that many were drowned in the depths of the fountain; and many were lost from his view, wandering in strange roads.

And great was the multitude that did enter into that strange building. And after they did enter into that building they did point the finger of scorn at me and those that were partaking of the fruit also; but we heeded them not.

- 34 Эдгээр нь миний эцгийн үгс буюу: Учир нь тэднийг анхаарсан болгон нь будилан одох ажгуу.
- 35 Мөн Лемен Лемүел хоёр тэр жимснээс хүртсэнгүй хэмээн эцэг минь хэлэв.
- 36 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг өөрийн зүүд буюу үзэгдлийн тухай тэрхүү бүх үгсийг ярьсны эцэст, тэрээр бидэнд хэлэв, үзэгдэлд харсан тэр зүйлүүдийнхээ учир, Лемен Лемүел хоёрын улмаас тэрээр үлэмж айв; тийм ээ, тэднийг Их Эзэний дэргэдээс зайлуулагдах болуузай хэмээн тэр айсан ажээ.
- 37 Мөн Их Эзэн тэднийг нигүүлсэн, зайлуулахгүй байж болохын тулд тэднийг өөрийнх нь үгийг дуулахыг, эцэг минь энэрэлт эцгийн бүхий л сэтгэлээр ухуулж, тийм ээ, эцэг минь тэдэнд номлон байв.
- 38 Мөн тэрбээр тэдэнд хандан номлосны дараа, мөн түүнчлэн тэдэнд олон зүйлийн тухай бошиглосны эцэст Их Эзэний зарлигуудыг дага хэмээн тэр тэдэнд тушаав; мөн тэр тэдэнд хандан ярьж байсныгаа зогсов.

These are the words of my father: For as many as heeded them, had fallen away.

And Laman and Lemuel partook not of the fruit, said my father.

And it came to pass after my father had spoken all the words of his dream or vision, which were many, he said unto us, because of these things which he saw in a vision, he exceedingly feared for Laman and Lemuel; yea, he feared lest they should be cast off from the presence of the Lord.

And he did exhort them then with all the feeling of a tender parent, that they would hearken to his words, that perhaps the Lord would be merciful to them, and not cast them off; yea, my father did preach unto them.

And after he had preached unto them, and also prophesied unto them of many things, he bade them to keep the commandments of the Lord; and he did cease speaking unto them.

## 1 Нифай 9

- 1 Мөнхүү эдгээр бүхий л зүйлийг тэрээр Лемүелийн хөндийд, майханд суурьшин байхдаа миний эцэг харж, бас сонсож, мөн ярьсан бөлгөө, мөн түүнчлэн эдгээр ялтсууд дээр бичигдэж эс чадах тэр бусад агуу олон зүйлийг буюу.
- 2 Мөн эдүгээ, би эдгээр ялтсуудын талаар ярьсанчлан, болгоогтун тэдгээр нь миний хүмүүсийн түүхийн бүрэн шастирыг дээр нь хийсэн тэр ялтсууд биш болой; учир нь би өөрийн хүмүүсийн бүрэн түүхийн шастирыг дээр нь хийсэн тэр ялтсуудад бибээр Нифайн хэмээх нэрийг өгсөн буюу; иймийн тул тэдгээр нь Нифайн ялтсууд хэмээн өөрийн минь нэрээр нэршив, мөн эдгээр ялтсууд түүнчлэн Нифайн ялтсууд хэмээн нэрлэгддэг бөлгөө.
- 3 Гэсэн хэдий ч, би эдгээр ялтсуудыг өөрийн хүмүүсийн тохинууллын шастирыг сийлэх онцгой зорилгын улмаас бүтээвэл зохино хэмээн Их Эзэнээс зарлиг хүлээн авсан болой би.
- 4 Нөгөө ялтсууд дээр хаадын засаглал, мөн миний хүмүүсийн дайнууд болон тэмцлийн шастир сийлэгдэх ёстой ажгуу; иймийн тул эдгээр ялтсууд нь тохиноуллын тухайд илүүтэй зориулагдах буюу; мөн нөгөө ялтсууд нь миний хүмүүсийн дайн болон тэмцэл бас хаадын засаглалыг тухайлахад илүүтэй зориулагдах болой.
- 5 Иймийн тул, эдгээр ялтсуудыг түүний мэргэн зорилгын тулд бүтээхийг Их Эзэн надад зарлигласан, миний мэдэх нь үгүй тэрхүү зорилго буюу.
- 6 Харин Их Эзэн бүх зүйлийг эхлэлээс нь мэдэх буюу; иймийн тул, тэрээр хүмүүний үрсийн дунд өөрийн бүхий л үйлүүдээ гүйцэлдүүлэх замыг бэлтгэх ажээ; учир нь болгоогтун, тэрбээр өөрийн бүх үгсийг биелэл болгох бүхий л хүчийг агуулах ажгуу. Мөн энэ нь ийн байх болой. Амен.

## 1 Nephi 9

And all these things did my father see, and hear, and speak, as he dwelt in a tent, in the valley of Lemuel, and also a great many more things, which cannot be written upon these plates.

And now, as I have spoken concerning these plates, behold they are not the plates upon which I make a full account of the history of my people; for the plates upon which I make a full account of my people I have given the name of Nephi; wherefore, they are called the plates of Nephi, after mine own name; and these plates also are called the plates of Nephi.

Nevertheless, I have received a commandment of the Lord that I should make these plates, for the special purpose that there should be an account engraven of the ministry of my people.

Upon the other plates should be engraven an account of the reign of the kings, and the wars and contentions of my people; wherefore these plates are for the more part of the ministry; and the other plates are for the more part of the reign of the kings and the wars and contentions of my people.

Wherefore, the Lord hath commanded me to make these plates for a wise purpose in him, which purpose I know not.

But the Lord knoweth all things from the beginning; wherefore, he prepareth a way to accomplish all his works among the children of men; for behold, he hath all power unto the fulfilling of all his words. And thus it is. Amen.

## 1 Нифай 10

- 1 Мөн эдүгээ би, Нифай, эдгээр ялтсууд дээр өөрийн явдал хэргийн тухай, мөн өөрийн засаглал болон тохинууллын тухай шастирыг үйлдэхээр зорих буюу, иймийн тул, өөрийн шастирыг үргэлжлүүлэхийн тулд би эцгийнхээ тухай зүйлүүдийн заримыг, мөн түүнчлэн ах нарынхаа тухай ярих ёстой бөлгөө.
- 2 Учир нь болгоогтун, мөнхүү улиран тохиох дор миний эцэг өөрийн яриаг зүүднийхээ тухай үгсээр, мөн түүнчлэн тэднийг бүхий л хүчээрээ чармайхыг ухуулан дуусгавар болгосны дараа, тэрээр тэдэнд хандан иудейчүүдийн талаар яriv—
- 3 Үүнчлэн тэд мөн бүр агуу хот Иерусалим устгагдсаны дараа, мөн олон нь олзлогдон Вавилонд хүргэгдэж, Их Эзэнээс тогтоосон тэр цаг нь ирэхээр, тэд дахин буцах бөлгөө, тийм ээ, бүр боолчлолоос гарч буцаан авчрагдах бөлгөө; мөн тэд боолчлолоос буцаж ирсний эцэст тэд өвийн нутгаа дахин эзэмших болой.
- 4 Тийм ээ, бүр миний эцэг Иерусалимыг орхисон цагаас зургаан зуун жилийн хойно, Их Эзэн Бурхан иудейчүүдийн дунд нэгэн бошиглогчийг төрүүлэх болно—бүр нэгэн Мессиаг, эсвээс, өөр үгээр, дэлхийн нэгэн Аврагчийг.
- 5 Мөн түүнчлэн тэрбээр бошиглогчдын талаар ярьсан бөлгөө, түүний тухайлан ярьсан тэрхүү Мессиагийн, эсвээс дэлхийн Гэтэлгэгчийн талаар гэрчилсэн тэд хичнээн олон тоотой билээ!
- 6 Иймийн тул, бүх хүмүүн төөрөлдсөн бас унасан байдалд ордог буюу, тэд энэхүү Гэтэлгэгчид тулгуурлахгүй бөгөөс үргэлжид тийм байх бөлгөө.
- 7 Мөн түүнчлэн тэрээр Их Эзэний замыг бэлтгэхээр, Мессиагийн өмнө ирэх нэгэн бошиглогчийн талаар өгүүлсэн ажгуу.
- 8 Тийм ээ, бүр тэрээр урагшлан мөн аглаг буйдад: Та нар Их Эзэний замыг бэлтгэцгээ, мөн түүний харгуйг шулуутга; учир нь та нарын эс мэдэх нэгэн дунд чинь зогсох бөлгөө; басхүү тэрээр надаас илүү хүчтэй, түүний шаахайн үдээсийг тайлах зохистой нь би биш хэмээн хашгирах бөлгөө. Мөн миний эцэг энэ зүйлийн талаар ихийг өгүүлсэн буюу.

## 1 Nephi 10

And now I, Nephi, proceed to give an account upon these plates of my proceedings, and my reign and ministry; wherefore, to proceed with mine account, I must speak somewhat of the things of my father, and also of my brethren.

For behold, it came to pass after my father had made an end of speaking the words of his dream, and also of exhorting them to all diligence, he spake unto them concerning the Jews—

That after they should be destroyed, even that great city Jerusalem, and many be carried away captive into Babylon, according to the own due time of the Lord, they should return again, yea, even be brought back out of captivity; and after they should be brought back out of captivity they should possess again the land of their inheritance.

Yea, even six hundred years from the time that my father left Jerusalem, a prophet would the Lord God raise up among the Jews—even a Messiah, or, in other words, a Savior of the world.

And he also spake concerning the prophets, how great a number had testified of these things, concerning this Messiah, of whom he had spoken, or this Redeemer of the world.

Wherefore, all mankind were in a lost and in a fallen state, and ever would be save they should rely on this Redeemer.

And he spake also concerning a prophet who should come before the Messiah, to prepare the way of the Lord—

Yea, even he should go forth and cry in the wilderness: Prepare ye the way of the Lord, and make his paths straight; for there standeth one among you whom ye know not; and he is mightier than I, whose shoe's latchet I am not worthy to unloose. And much spake my father concerning this thing.

- 9 Мөн Иорданы цаад талд Бетабарад тэр баптисм хүртээх ёстой хэмээн миний эцэг хэлэв; мөн түүнчлэн тэрээр баптисм хүртээх болно; бүр тэрээр Мессиад баптисм хүртээх болно хэмээн тэр хэлэв.
- 10 Мөн тэр Мессиад баптисм хүртээсний дараа, тэрээр бүх дэлхийн нүглийг үүрэх ёстой түүнийг, Бурханы Хурганд баптисм хүртээснээ гэрчлэн мөн нотлон өгүүлэх болно.
- 11 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь эдгээр үгсийг ярьсныхаа дараа миний ах нарт хандан тэрээр иудейчүүдийн дунд номлогдох сайн мэдээний талаар, мөн түүнчлэн Иудейчүүдийн итгэлгүйдээ бууран доройтох талаар ярьсан бөлгөө. Мөн тэр ирэх ёстой Мессиаг тэд алсны дараа, мөн тэрээр алагдсаныхаа дараа тэр үхлээс босох болно, мөн Ариун Сүнсээр өөрийгөө харийнханд үзүүлэх болно.
- 12 Тийм ээ, түүгээр үл барам эцэг минь ихийг өгүүлсэн билээ, харийнханы талаар, мөн түүнчлэн Израилын угсааны талаар, мөчрүүд нь хугаран бүх дэлхийн гадаргуугаар тараагдах тэр, чидуны модтой адилтгам байх буюу хэмээв.
- 13 Иймийн тул, тэрээр бид бүх дэлхийн гадаргуугаар тараагдах болно хэмээсэн Их Эзэний үг гүйцэлдэхийн тулд бид амлалтын нутгийн зүг нэгэн зорилготойгоор удирдагдах нь гарцаагүйг хэлсэн ажгуу.
- 14 Мөн Израилын угсаа тараагдсаны дараа дахин хамтдаа нэгдэн цуглуулагдана; өөрөөр хэлбэл чухамдаа харийнхан Бурханы Сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсны дараа, чидуны модны унаган мөчрүүд буюу Израилын угсаанаас үлдэгсэд нь үүнд залгагдах болно, өөрөөр хэлбэл үнэн Мессиагийн, Их Эзэнийхээ болон Гэтэлгэгчийнхээ мэдлэгт орох болно.
- 15 Мөн миний эцэг ийм маягийн хэлээр ах нарт маань хандан ярьж бас бошиглосон бөлгөө, мөн түүнчлэн миний энэ номонд эс бичиглэх өөр олон зүйлийг; учир нь бибээр тэдгээрээс минийхээр зүйд нийцэх болгоныг нь өөрийн нөгөө номонд бичиглэсэн бөлгөө.
- 16 Мөн миний тухайлан өгүүлсэн эдгээр бүхий л зүйлийг эцэг минь Лемүелийн хөндийд майханд аж төрөн байхдаа үйлдэв.

And my father said he should baptize in Bethabara, beyond Jordan; and he also said he should baptize with water; even that he should baptize the Messiah with water.

And after he had baptized the Messiah with water, he should behold and bear record that he had baptized the Lamb of God, who should take away the sins of the world.

And it came to pass after my father had spoken these words he spake unto my brethren concerning the gospel which should be preached among the Jews, and also concerning the dwindling of the Jews in unbelief. And after they had slain the Messiah, who should come, and after he had been slain he should rise from the dead, and should make himself manifest, by the Holy Ghost, unto the Gentiles.

Yea, even my father spake much concerning the Gentiles, and also concerning the house of Israel, that they should be compared like unto an olive tree, whose branches should be broken off and should be scattered upon all the face of the earth.

Wherefore, he said it must needs be that we should be led with one accord into the land of promise, unto the fulfilling of the word of the Lord, that we should be scattered upon all the face of the earth.

And after the house of Israel should be scattered they should be gathered together again; or, in fine, after the Gentiles had received the fulness of the Gospel, the natural branches of the olive tree, or the remnants of the house of Israel, should be grafted in, or come to the knowledge of the true Messiah, their Lord and their Redeemer.

And after this manner of language did my father prophesy and speak unto my brethren, and also many more things which I do not write in this book; for I have written as many of them as were expedient for me in mine other book.

And all these things, of which I have spoken, were done as my father dwelt in a tent, in the valley of Lemuel.



- 17 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, эцгийнхээ бүх үгсийг, түүний үзэгдэлд харсан тэдгээр зүйлүүдийн талаар, мөн түүнчлэн тэрбээр Бурханы Хүүд итгэлтэй байснаар хүлээн авсан тэрхүү хүч болох Ариун Сүнсний хүчээр түүний ярьсан тэдгээр зүйлийг сонсоны дараа—мөн Бурханы Хүү нь тэрхүү ирэх ёстой Мессиа байсан бөлгөө—хуучин цагийн адилаар, хүмүүний үрсэд тэрээр өөрийгөө харуулах тэр цагт ч түүнийг хичээнгүйлэн хайгч хэн бүхэнд Бурханы бэлэг болох Ариун Сүнсний хүчээр эдгээр зүйлсийг би, Нифай, түүнчлэн өөрөө харж бас сонсож, түүнчлэн мэдэхийг хүсч байлаа.
- 18 Учир нь тэр өчигдөр, өнөөдөр бас үргэлжид адил байх буюу; мөн хэрэв тэд тэрчлэн наманчилж мөн түүнд ирвээс, бүх хүмүүнд энэ дэлхийн үүслээс зам бэлтгэгдсэн байдаг бөлгөө.
- 19 Учир нь хичээнгүйлэн хайгч тэр олох болно; мөн Бурханы нууцууд нь тэдэнд энэ цагт ч хуучин цагийн адил, мөн ирэх цагийн адилаар хуучин цагт ч Ариун Сүнсний хүчээр задлагдах ажгуу; иймийн тул, Их Эзэний замнал нэгэн мөнхийн эргэлт авай.
- 20 Тиймийн тул сана, ай хүмүүн та нар, өөрийн бүхий л үйлийнхээ тул та нар шүүлтэнд хүргэгдэх бөлгөө.
- 21 Иймийн тул, хэрэв та нар сорилтынхоо өдрүүдэд ёсон бусыг үйлдэхийг эрэлхийлсэн аваас, тэгвэл та нар Бурханы шүүлтгийн суудлын өмнө цэвэр бус нь тогтоогдоно; мөн цэвэр бус нэгээхэн ч зүйл Бурхантай хамт оршиж эс чадна; иймийн тул, та нар үүрд хаягдах ёстой болно.
- 22 Мөн эдгээр зүйлсийг ярих эрх мэдлийг Ариун Сүнс надад өгсөн бөлгөө, мөн тэдгээрийг үгүйсгэх нь үгүй.

And it came to pass after I, Nephi, having heard all the words of my father, concerning the things which he saw in a vision, and also the things which he spake by the power of the Holy Ghost, which power he received by faith on the Son of God—and the Son of God was the Messiah who should come—I, Nephi, was desirous also that I might see, and hear, and know of these things, by the power of the Holy Ghost, which is the gift of God unto all those who diligently seek him, as well in times of old as in the time that he should manifest himself unto the children of men.

For he is the same yesterday, today, and forever; and the way is prepared for all men from the foundation of the world, if it so be that they repent and come unto him.

For he that diligently seeketh shall find; and the mysteries of God shall be unfolded unto them, by the power of the Holy Ghost, as well in these times as in times of old, and as well in times of old as in times to come; wherefore, the course of the Lord is one eternal round.

Therefore remember, O man, for all thy doings thou shalt be brought into judgment.

Wherefore, if ye have sought to do wickedly in the days of your probation, then ye are found unclean before the judgment-seat of God; and no unclean thing can dwell with God; wherefore, ye must be cast off forever.

And the Holy Ghost giveth authority that I should speak these things, and deny them not.

## 1 Нифай 11

- 1 Учир нь улиран тохиох дор би эцгийнхээ үзсэн тэр зүйлийг мэдэхийг хүссэний дараа, мөн Их Эзэн тэдгээрийг надад мэдүүлж болно хэмээн итгэсээр авай, би ийн дотроо тунгаан суух зуур би Их Эзэний Сүнсэнд автагдан алсад одож, тийм ээ, миний урьд өмнө нь хэзээ ч хараагүй, мөн миний хэзээ ч урьд нь хөл тавьж байгаагүй үлэмж өндөр ууланд гарлаа.
- 2 Мөн Сүнс надад хандан: Болгоогтун, юуг хүснэв та? хэмээв.
- 3 Мөн би: Эцгийнхээ үзсэн тэр зүйлийг би харах хүсэлтэй гэв.
- 4 Мөн Сүнс надад хандан: Эцгийнхээ өгүүлсэн тэрхүү модыг тэрээр харсан хэмээн та итгэнэ үү
- 5 Мөн би хэлэв: Тийм ээ, эцгийнхээ бүх үгсэд миний итгэдгийг та мэдэх буйза.
- 6 Мөн би эдгээр үгсийг ярихад Сүнс өндөр дуугаар хашгирч, өгүүлсэн нь: Бүхний дээд Бурхан Их Эзэнд Хосанна; учир нь тэр бүх дэлхийн Бурхан, тийм ээ, бүр бүхнээс дээгүүр ажгуу. Мөн адислагдсан болой та, Нифай, бүхний дээд Бурханы Хүүд та итгэдгийн учир бөлгөө; иймийн тул та хүссэн зүйлүүдээ харах болно.
- 7 Мөн болгоогтун энэ зүйл тэмдгээр танд өгөгдөх болно, эцгийн тань амссан тэр жимсийг өгөгч модыг та харсны дараа, та түүнчлэн тэнгэрээс доошлон буух хүнийг ажин, мөн та түүнийг гэрчлэх болно; мөн та түүнийг гэрчилснийхээ дараа энэ бол Бурханы Хүү юм гэдгийг та нотлон өгүүлэх болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Сүнс надад хандан: Харагтун! хэмээв. Мөн би харвал модыг ажив; мөн энэ нь миний эцгийн үзсэн модтой эгээ адил байсан бөлгөө; мөн үүний үзэсгэлэн нь нэвт, тийм ээ, бүх үзэсгэлэнтээс үлэмж; мөн түүний цайрах нь будрах цасны цайрахаас ч үлэмж бөлгөө.
- 9 Мөнхүү улиран тохиох дор би модыг хараад, Сүнсэнд хандан: Та надад бүхнээс эрхэм дээд тэр модыг үзүүлснийг би ухаарав хэмээн хэлэв.
- 10 Мөн тэрээр надад: Юуг хүснэв та? хэмээв.

## 1 Nephi 11

For it came to pass after I had desired to know the things that my father had seen, and believing that the Lord was able to make them known unto me, as I sat pondering in mine heart I was caught away in the Spirit of the Lord, yea, into an exceedingly high mountain, which I never had before seen, and upon which I never had before set my foot.

And the Spirit said unto me: Behold, what desirest thou?

And I said: I desire to behold the things which my father saw.

And the Spirit said unto me: Believest thou that thy father saw the tree of which he hath spoken?

And I said: Yea, thou knowest that I believe all the words of my father.

And when I had spoken these words, the Spirit cried with a loud voice, saying: Hosanna to the Lord, the most high God; for he is God over all the earth, yea, even above all. And blessed art thou, Nephi, because thou believest in the Son of the most high God; wherefore, thou shalt behold the things which thou hast desired.

And behold this thing shall be given unto thee for a sign, that after thou hast beheld the tree which bore the fruit which thy father tasted, thou shalt also behold a man descending out of heaven, and him shall ye witness; and after ye have witnessed him ye shall bear record that it is the Son of God.

And it came to pass that the Spirit said unto me: Look! And I looked and beheld a tree; and it was like unto the tree which my father had seen; and the beauty thereof was far beyond, yea, exceeding of all beauty; and the whiteness thereof did exceed the whiteness of the driven snow.

And it came to pass after I had seen the tree, I said unto the Spirit: I behold thou hast shown unto me the tree which is precious above all.

And he said unto me: What desirest thou?

11 Мөн би түүнд хандаж: Түүний чухам юу өгүүлж буйг мэдэхийг хүснэм хэмээв—учир нь би түүнтэй хүнтэй ярихын адилаар ярив; учир нь, тэрээр хүмүүний хэлбэртэй байсныг би ажигласан; тийм хэдий ч, тэр Их Эзэний Сүнс байсныг би мэдсэн бөлгөө; мөн тэр надад хандан нэг хүн нөгөөтэйгөө ярихын адил ярьсан буюу.

12 Мөнхүү улиран тохиох дор тэр надад хандан: **Харагтун! хэмээв.** Мөн би түүний зүг харвал, мөн би түүнийг үзсэнгүй; учир нь тэрээр миний дэргэдээс холдон одсон байлаа.

13 Мөнхүү улиран тохиох дор би харж басхүү их хот Иерусалимыг, мөн түүнчлэн бусад хотуудыг үзэв. Мөн би Назар хотыг үзэв; бас Назар хот дахь онгон бүсгүйг би харав, мөн тэрбээр үлэмж хонгор мөн цагаан байлаа.

14 Мөнхүү улиран тохиох дор тэнгэр нээгдэхийг үзэв би; мөн тэнгэр элч доош бууж мөн миний өмнө зогсов; мөн тэрээр надад хандан: **Нифай, юуг харнав та? хэмээв.**

15 Мөн би түүнд хандан: **Онгон бүсгүйг, бусад бүх онгон бүсгүйчүүдээс илүү хамгийн үзэсгэлэн гоо бас хонгорхон түүнийг, хэмээв.**

16 Мөн тэр надад хандан: **Бурханы хүлцлийг мэдэх үү та? хэмээв.**

17 Мөн би түүнд хандан: **Тэрбээр хүүхдүүддээ хайртайг нь мэднэ би; тийм боловч, бүх зүйлүүдийн утгыг мэдэх нь үгүй би хэмээв.**

18 Мөн тэр надад хандан: **Болгоогтун, таны харж буй тэр онгон бүсгүй бол Бурханы Хүүгийн махан бодийн биеийг төрүүлэгч эх нь бөлгөө хэмээв.**

19 Мөнхүү улиран тохиох дор тэр бүсгүйг Сүнс авч одохыг би харав; мөн Сүнс бүсгүйг авч одсоны дараа хэсэг байзнаад тэнгэр элч надад хандан: **Харагтун! хэмээв.**

20 Мөн би сайхь онгон бүсгүйг дахин харж, гар дээрээ хүүхэд тэвэрсэн байхыг болгоов.

21 Мөн тэнгэр элч надад хандан: **Бурханы Хургыг, тийм ээ, бүр Мөнхийн Эцэгийн Хүүг болгоогтун! Эцгийнхээ харсан тэр мод ямар утгатайг мэдэв үү, та? хэмээв.**

And I said unto him: To know the interpretation thereof—for I spake unto him as a man speaketh; for I beheld that he was in the form of a man; yet nevertheless, I knew that it was the Spirit of the Lord; and he spake unto me as a man speaketh with another.

And it came to pass that he said unto me: Look! And I looked as if to look upon him, and I saw him not; for he had gone from before my presence.

And it came to pass that I looked and beheld the great city of Jerusalem, and also other cities. And I beheld the city of Nazareth; and in the city of Nazareth I beheld a virgin, and she was exceedingly fair and white.

And it came to pass that I saw the heavens open; and an angel came down and stood before me; and he said unto me: Nephi, what beholdest thou?

And I said unto him: A virgin, most beautiful and fair above all other virgins.

And he said unto me: Knowest thou the condescension of God?

And I said unto him: I know that he loveth his children; nevertheless, I do not know the meaning of all things.

And he said unto me: Behold, the virgin whom thou seest is the mother of the Son of God, after the manner of the flesh.

And it came to pass that I beheld that she was carried away in the Spirit; and after she had been carried away in the Spirit for the space of a time the angel spake unto me, saying: Look!

And I looked and beheld the virgin again, bearing a child in her arms.

And the angel said unto me: Behold the Lamb of God, yea, even the Son of the Eternal Father! Knowest thou the meaning of the tree which thy father saw?

22 Мөн би түүнд хариулж, өгүүлсэн нь: Тийм ээ, энэ бол хүмүүний үрсийн зүрхэнд хааяагүй түгэх Бурханы хайр; иймийн тул, энэ нь бүхнээс илүү, хамгийн ихээр хүслийг татагч буюу.

23 Мөн тэрээр надад хандан ярьж, өгүүллүүн: Тийм ээ, мөн бодгальд хамгийн их баясгалант болой.

24 Мөн тэрээр эдгээр үгсийг ярьсныхаа дараа, тэрбээр надад хандан: Харагтун! хэмээв. Мөн би харвал, тийнхүү Бурханы Хүү хүмүүний үрсийн дунд явж байхыг би ажиглав; мөн олон нь түүний хөлд унан бас түүнийг бишрэхийг үзэв би.

25 Мөнхүү улиран тохиох дор миний эцгийн үзсэн тэр төмөр бариул нь Бурханы үг байсныг би мэдэв; тэр нь амьдралын усан оргилуур уруу эсвээс амьдралын мод уруу удирдах ажгуу; тэр ус нь Бурханы хайрын бэлэгдэл ажгуу; мөн түүнчлэн уг мод Бурханы хайрыг илтгэж буйг би ухаарав.

26 Мөн тэнгэр элч надад дахин хандаж: Харагтун мөн Бурханы хүлцлийг болгоогтун! хэмээв.

27 Мөн би харж бас эцгийнхээ ярьсан дэлхийн Гэтэлгэгчийг болгоов; мөн түүнчлэн түүний өмнө замыг нь бэлтгэх нэгэн бошиглогчийг би болгоов. Мөн Бурханы Хурга урагш явж түүгээр баптисм хүртэв; мөн тэрбээр баптисм хүртсэний дараа, тэнгэр нээгдэж мөн Ариун Сүнс тэнгэрээс тагтаа хэлбэртэйгээр бууж мөн түүн дээр тогтнохыг би болгоов.

28 Мөн тэрээр хүмүүст их хүч бас агуу их алдар суугаар тохинуулж урагшлан явахыг би болгоов; мөн ард олон түүнийг сонсохоор нэгдэн цугларч байв; мөн тэд түүнийг өөрсдийн дундаас зайлуулан хөөснийг би ажиглав.

29 Мөн түүнчлэн түүнийг дагалдах бусад арванхоёрыг би болгоов. Мөнхүү улиран тохиох дор Сүнс тэднийг миний өмнөөс авч одов, мөн би тэднийг харсан нь үгүй.

30 Мөнхүү улиран тохиох дор тэнгэр элч надад хандан дахин ярьж өгүүлсэн нь: Харагтун! Мөн би харав, мөн тэнгэр дахин нээгдэхийг би болгоов, мөн тэнгэр элчүүд хүмүүний үрсийн дээр хүрэлцэн ирэхийг би үзэв; мөн тэд тэдэнд тохинуулсан бөлгөө.

And I answered him, saying: Yea, it is the love of God, which sheddeth itself abroad in the hearts of the children of men; wherefore, it is the most desirable above all things.

And he spake unto me, saying: Yea, and the most joyous to the soul.

And after he had said these words, he said unto me: Look! And I looked, and I beheld the Son of God going forth among the children of men; and I saw many fall down at his feet and worship him.

And it came to pass that I beheld that the rod of iron, which my father had seen, was the word of God, which led to the fountain of living waters, or to the tree of life; which waters are a representation of the love of God; and I also beheld that the tree of life was a representation of the love of God.

And the angel said unto me again: Look and behold the condescension of God!

And I looked and beheld the Redeemer of the world, of whom my father had spoken; and I also beheld the prophet who should prepare the way before him. And the Lamb of God went forth and was baptized of him; and after he was baptized, I beheld the heavens open, and the Holy Ghost come down out of heaven and abide upon him in the form of a dove.

And I beheld that he went forth ministering unto the people, in power and great glory; and the multitudes were gathered together to hear him; and I beheld that they cast him out from among them.

And I also beheld twelve others following him. And it came to pass that they were carried away in the Spirit from before my face, and I saw them not.

And it came to pass that the angel spake unto me again, saying: Look! And I looked, and I beheld the heavens open again, and I saw angels descending upon the children of men; and they did minister unto them.

- 31 Мөн тэрээр дахин надад хандаж, хэлрүүн: Харагтун! хэмээв. Мөн би харав, бас Бурханы Хурга хүмүүний үрсийн дунд урагшлан явахыг би болгоов. Мөн өвчилсөн, бас олон зүйл өвчний улмаас, мөн чөтгөрүүд болон бузар сүнстэйн улмаас зовж шаналсан олныг би болгоов; мөнхүү тэнгэр элч ярьж, бас эдгээр бүх зүйлийг надад үзүүлсэн авай. Мөн тэд Бурханы Хурганы хүчээр эдгээгдэв; мөн чөтгөрүүд болон бузар сүнснүүд зайлуулагдав.
- 32 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан дахин ярьж, хэлсэн нь: Харагтун! Мөн би харж бас Бурханы Хургыг, тэрээр хүмүүст баригдсаныг нь болгоов; тийм ээ, Үүрдийн Бурханы Хүү дэлхийнхээр шүүгдэв; мөн би харсан бөгөөд бас гэрчлэх буюу.
- 33 Мөн би, Нифай, тэрбээр энэ дэлхийн нүглүүдийн тул загалмайд өргөгдөн мөн алагдсаныг үзсэн бөлгөө.
- 34 Мөн түүнийг алагдсаны дараа би газар дэлхийн олныг, Их Эзэний тэнгэр элчээр Хурганы төлөөлөгч хэмээн нэрлэгдсэн арванхоёрын эсрэг тэмцэхээр тэд хамтран цугларсныг үзэв.
- 35 Мөн газар дэлхийн олон нь хамтран цугларав; мөн тэд миний эцгийн үзсэн барилгын адил том бөгөөд нүсэр байшинд байсныг би үзэв. Мөн Их Эзэний тэнгэр элч надад хандан дахин ярьж, хэлрүүн: Дэлхий болон түүний мэргэн ухааныг болгоогтун; тийм ээ, Израилын угсаа Хурганы арванхоёр төлөөлөгчийн эсрэг тэмцэхээр хамтран цугларсныг болгоогтун.
- 36 Мөнхүү улиран тохиох дор тэр агуу хийгээд нүсэр барилга нь дэлхийн бардамнал байсныг би үзсэн бас гэрчилнэ; мөн энэ нь унав, мөн түүний уналт үлэмж аймшигтай буюу. Мөн Их Эзэний тэнгэр элч дахин надад хандан ярьж хэлрүүн: Хурганы арванхоёр төлөөлөгчийн эсрэг тэмцэх бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсийн устгал ийн тохиох ажгуу.

And he spake unto me again, saying: Look! And I looked, and I beheld the Lamb of God going forth among the children of men. And I beheld multitudes of people who were sick, and who were afflicted with all manner of diseases, and with devils and unclean spirits; and the angel spake and showed all these things unto me. And they were healed by the power of the Lamb of God; and the devils and the unclean spirits were cast out.

And it came to pass that the angel spake unto me again, saying: Look! And I looked and beheld the Lamb of God, that he was taken by the people; yea, the Son of the everlasting God was judged of the world; and I saw and bear record.

And I, Nephi, saw that he was lifted up upon the cross and slain for the sins of the world.

And after he was slain I saw the multitudes of the earth, that they were gathered together to fight against the apostles of the Lamb; for thus were the twelve called by the angel of the Lord.

And the multitude of the earth was gathered together; and I beheld that they were in a large and spacious building, like unto the building which my father saw. And the angel of the Lord spake unto me again, saying: Behold the world and the wisdom thereof; yea, behold the house of Israel hath gathered together to fight against the twelve apostles of the Lamb.

And it came to pass that I saw and bear record, that the great and spacious building was the pride of the world; and it fell, and the fall thereof was exceedingly great. And the angel of the Lord spake unto me again, saying: Thus shall be the destruction of all nations, kindreds, tongues, and people, that shall fight against the twelve apostles of the Lamb.

## 1 Нифай 12

- 1 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан: Хар, мөн үр удмаа, мөн түүнчлэн ах нарынхаа удмыг болгоогтун хэмээв. Мөн би харваас, амлалтын нутгийг болгоов; мөн би цугласан олон хүмүүсийг ажиглав, тийм ээ, бүр тоогоороо тэнгисийн элсний ширхэг лугаа адил тийм олон байсан ажгуу.
- 2 Мөнхүү улиран тохиох дор нэг нэгнийхээ эсрэг тулалдахаар бөөгнөрөн цугларсан олныг би болгоов; мөн дайнууд, мөн дайны цуурхлууд, мөн миний хүмүүсийн дундаас илдэнд эрсдэх асар олныг би олж харав.
- 3 Мөнхүү улиран тохиох дор олон үе, тэр нутагт дайн тулаанууд мөн хэрүүл тэмцлийн дунд улиран өнгөрөхийг би ажиглав; мөн олон хот, тийм ээ, бүр миний бие тоолшгүй тийм олон тэднийг бибээр олж харав.
- 4 Мөнхүү улиран тохиох дор амлалтын нутгийн гадаргуу дахь харанхуй мананг би үзэв; мөн би цахилгаан гялбахыг харав, бас тэнгэр дуугаран мөн газар хөдлөх, бас олон янзын нүргээнт чимээг би сонсов; мөн газар болон хад чулууг, тэдгээр нь хагаран цуурахыг би үзэв; мөн уулс хэдэн хэсэг болон нурж унахыг би харав; мөн би тал газруудыг, тэдгээр нь ан цавгаран эвдрэхийг би үзэв; мөн би олон хот, тэдгээр нь живүүлэгдсэнийг харав; мөн түймэрт шатаагдсан тэдгээр олныг би үзэв; мөн доргин хөдлөхийн учир, хөсөр унах олныг би үзэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор эдгээр зүйлийг үзсэний дараа би харанхуйлах мананг, энэ нь газрын гадаргуугаас арилан одохыг би үзэв; мөн болгоогтун, Их Эзэний агуу хийгээд аймшигт шүүлтийн учир унаагүй олон хүнийг би үзэв.
- 6 Мөн тэнгэр нээгдэж Бурханы Хурга тэнгэрээс бууж ирэхийг би үзэв; мөн тэрбээр бууж ирээд басхүү тэдэнд өөрийгөө үзүүлсэн бөлгөө.
- 7 Мөн би Ариун Сүнс бусад арванхоёр дээр бууж ирэхийг түүнчлэн үзэж, басхүү гэрчлэв; мөн тэд Бурханаас томилогдсон хийгээд сонгогдсон бөлгөө.
- 8 Мөн сайхь тэнгэр элч надад хандан ярьж, хэлсэн нь: Таны үр удамд тохинуулахаар сонгогдсон Хурганы арванхоёр шавийг болгоогтун хэмээв.

## 1 Nephi 12

And it came to pass that the angel said unto me: Look, and behold thy seed, and also the seed of thy brethren. And I looked and beheld the land of promise; and I beheld multitudes of people, yea, even as it were in number as many as the sand of the sea.

And it came to pass that I beheld multitudes gathered together to battle, one against the other; and I beheld wars, and rumors of wars, and great slaughters with the sword among my people.

And it came to pass that I beheld many generations pass away, after the manner of wars and contentions in the land; and I beheld many cities, yea, even that I did not number them.

And it came to pass that I saw a mist of darkness on the face of the land of promise; and I saw lightnings, and I heard thunders, and earthquakes, and all manner of tumultuous noises; and I saw the earth and the rocks, that they rent; and I saw mountains tumbling into pieces; and I saw the plains of the earth, that they were broken up; and I saw many cities that they were sunk; and I saw many that they were burned with fire; and I saw many that did tumble to the earth, because of the quaking thereof.

And it came to pass after I saw these things, I saw the vapor of darkness, that it passed from off the face of the earth; and behold, I saw multitudes who had not fallen because of the great and terrible judgments of the Lord.

And I saw the heavens open, and the Lamb of God descending out of heaven; and he came down and showed himself unto them.

And I also saw and bear record that the Holy Ghost fell upon twelve others; and they were ordained of God, and chosen.

And the angel spake unto me, saying: Behold the twelve disciples of the Lamb, who are chosen to minister unto thy seed.

- 9 Мөн тэрбээр надад: Та Хурганы арванхоёр төлөөлөгчийг санаж байна уу? Болгоогтун, тэд бол Израилын арванхоёр овгийг шүүх тэдгээр бөлгөө; иймийн тул, таны үр удмын арванхоёр тохинуулагч нь тэднээр шүүгдэх болно; та бүгд Израилын угсааных учраас болой.
- 10 Мөн таны болгоож буй эдгээр арванхоёр тохинуулагч нь таны үр удмыг шүүх болно. Мөн болгоогтун, тэд үүрд зөв шударга бөлгөө; учир юун хэмээвээс Бурханы Хурганд итгэх тэдний итгэлийн учир тэдний өмсгөл түүний цусанд цагаан болгогдсон бөлгөө.
- 11 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Харагтун! хэмээв. Мөн би харж, бас гурван үе зөв шударгаар улиран өнгөрөхийг болгоов; мөн тэдний өмсгөл бүр Бурханы Хурганыхтай адилтгам цагаан байсан болой. Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Тэд түүнд итгэлтэйн учир, эдгээр нь Хурганы цусанд цагаан болгогджээ хэмээв.
- 12 Мөн би, Нифай, түүнчлэн дөрөв дэх үеэс олонх нь зөв шударга байдалд улиран өнгөрөхийг харсан бөлгөө.
- 13 Мөнхүү улиран тохиох дор газар дэлхийн олон түмэн хамтран цуглахыг би харав.
- 14 Мөн сайхь тэнгэр элч надад: өөрийн үр удмыг, мөн түүнчлэн ах нарынхаа үр удмыг болгоогтун хэмээв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор би харж бас миний үр удам олон олноороо ах нарын маань үр удмын эсрэг хамтран цугларсан байхыг болгоов; мөн тэд тулалдахаар нэг дор цугларчээ.
- 16 Мөн сайхь тэнгэр элч надад хандан, өгүүлсэн нь: Эцгийнхээ үзсэн тэр буртаглагдсан усны эхийг болгоогтун; тийм ээ, бүр түүний тухайлан ярьсан тэр голыг; мөн түүний гүн нь тамын ёроол бөлгөө.
- 17 Мөн харанхуйлах манан нь чөтгөрийн уруу таталт, тэр нь хүмүүний үрсийн мэлмийг сохолж зүрхийг хатууруулж, мөн өргөн замаар тэднийг удирдан, чингээд тэд мөхөж, төөрөлдөх бөлгөө.

And he said unto me: Thou rememberest the twelve apostles of the Lamb? Behold they are they who shall judge the twelve tribes of Israel; wherefore, the twelve ministers of thy seed shall be judged of them; for ye are of the house of Israel.

And these twelve ministers whom thou beholdest shall judge thy seed. And, behold, they are righteous forever; for because of their faith in the Lamb of God their garments are made white in his blood.

And the angel said unto me: Look! And I looked, and beheld three generations pass away in righteousness; and their garments were white even like unto the Lamb of God. And the angel said unto me: These are made white in the blood of the Lamb, because of their faith in him.

And I, Nephi, also saw many of the fourth generation who passed away in righteousness.

And it came to pass that I saw the multitudes of the earth gathered together.

And the angel said unto me: Behold thy seed, and also the seed of thy brethren.

And it came to pass that I looked and beheld the people of my seed gathered together in multitudes against the seed of my brethren; and they were gathered together to battle.

And the angel spake unto me, saying: Behold the fountain of filthy water which thy father saw; yea, even the river of which he spake; and the depths thereof are the depths of hell.

And the mists of darkness are the temptations of the devil, which blindeth the eyes, and hardeneth the hearts of the children of men, and leadeth them away into broad roads, that they perish and are lost.

18 Мөн таны эцгийн харсан тэр агуу хийгээд нүсэр барилга нь хүмүүний үрсийн хоосон төсөөлөл болоод бардамнал болой. Мөн асар том бөгөөд аймшигтай ангал тэднийг тусгаарлах бөлгөө; тийм ээ, бүр Мөнхийн Бурханы, энэ дэлхийн эхлэлээс эдүгээг хүртэл, мөн энэ цаг үеэс хойшид мөн үүрд Ариун Сүнсний гэрчлэх Бурханы Хурга болон Мессиагийн шударга ёсны үг бөлгөө хэмээв.

19 Мөн тэнгэр элч эдгээр үгсийг ярих зуур, би харж мөн ах нарын маань үр удам тэнгэр элчийн хэлсэнчлэн миний үр удмынхны эсрэг тэмцэхийг үзэв; мөн миний үр удмын бардам зан, мөн чөтгөрийн уруу таталтын улмаас ах нарын маань үр удам миний үр удмыг давамгайлахыг би ажиглав.

20 Мөнхүү улиран тохиох дор би харж ах нарын маань үр удмын хүмүүс миний үр удмыг ялсан байхыг болгоов; мөн тэд хэсэг бүлгээрээ нутгийн гадаргуугаар урагшлан явж байсан бөлгөө.

21 Мөн тэд хэсэг бүлгээрээ нэгдэн цугларахыг би үзэв; мөн би тэдний дундах дайн тулаан болон дайны цуурхлуудыг үзэв; мөн дайн тулаан болон дайны цуурхлын дунд олон үе улиран өнгөрөхийг би харав.

22 Мөн уг тэнгэр элч надад хандан: Болгоогтун, эдгээр нь итгэлгүйдээ бууран доройтох болно хэмээв.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд итгэлгүйдээ бууран доройтсоны дараа тэд харанхуй бас зэвүүцэм, басхүү буртаглагдсан хүмүүс болж, залхаг хийгээд зүйл бүрийн жигшүүрт үйлээр дүүрснийг харсан бөлгөө.

And the large and spacious building, which thy father saw, is vain imaginations and the pride of the children of men. And a great and a terrible gulf divideth them; yea, even the word of the justice of the Eternal God, and the Messiah who is the Lamb of God, of whom the Holy Ghost beareth record, from the beginning of the world until this time, and from this time henceforth and forever.

And while the angel spake these words, I beheld and saw that the seed of my brethren did contend against my seed, according to the word of the angel; and because of the pride of my seed, and the temptations of the devil, I beheld that the seed of my brethren did overpower the people of my seed.

And it came to pass that I beheld, and saw the people of the seed of my brethren that they had overcome my seed; and they went forth in multitudes upon the face of the land.

And I saw them gathered together in multitudes; and I saw wars and rumors of wars among them; and in wars and rumors of wars I saw many generations pass away.

And the angel said unto me: Behold these shall dwindle in unbelief.

And it came to pass that I beheld, after they had dwindled in unbelief they became a dark, and loathsome, and a filthy people, full of idleness and all manner of abominations.



## 1 Нифай 13

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэнгэр элч надад ярьж, хэлрүүн: Харагтун! Мөн би харж бас олон үндэстэн болон хаант гүрнүүдийг болгоов.
- 2 Мөн сайхь тэнгэр элч надад: Юуг болгооно вэ? хэмээв. Мөн би: Миний бие олон үндэстэн болоод хаант улсуудыг болгооно хэмээв.
- 3 Мөн тэрээр надад хандан: Эдгээр нь харийнханы үндэстнүүд болон хаант улсууд бөлгөө хэмээв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор би харийнханы үндэстнүүдийн дунд агуу сүмийн үүслийг харав.
- 5 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Бусад бүх сүмүүдээс хамгийн жигшүүрт, Бурханы гэгээнтнүүдийг хороогч, тийм ээ, тэднийг тарчилгаж бас тэднийг буулгалан, мөн төмөр буулганд тэднийг хөллөн, мөн тэднийг боолчлолд хүргэгч тэрхүү сүмийн үүслийг болгоогтун хэмээв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор би энэхүү агуу хийгээд жигшүүрт сүмийг болгоов; мөн үүнийг үүсгэгч нь чөтгөр байсныг би харав.
- 7 Мөн түүнчлэн би алт, бас мөнгө, бас торго, бас гал улаан нөмрөг, бас нарийн нэхээст эд, бас бүх төрлийн тансаг хувцсыг би харав; мөн олон янхан эмсийг би харсан бөлгөө.
- 8 Мөн сайхь тэнгэр элч надад хандан ярьж, өгүүлсэн нь: Алтыг, бас мөнгийг, торгыг, гал улаан нөмрөгийг, бас нарийн нэхээст эдийг, тансаг хувцсыг, бас янхан эмсийг болгоогтун, эдгээр нь энэ агуу хийгээд жигшүүрт сүмийн хүслэн болохыг буюу.
- 9 Мөн түүнчлэн тэд дэлхийн магтаалын төлөө Бурханы гэгээнтнүүдийг устгаж, мөн тэднийг боолчлолд оруулах бөлгөө.
- 10 Мөнхүү улиран тохиох дор би харж мөн их усыг болгоов; мөн тэр нь харийнханыг миний ах нарын үр удмаас тусгаарлаж байв.
- 11 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан хэлэв: Болгоогтун Бурханы хилэгнэл ах нарын тань үр удам дээр байх буюу.

## 1 Nephi 13

And it came to pass that the angel spake unto me, saying: Look! And I looked and beheld many nations and kingdoms.

And the angel said unto me: What beholdest thou? And I said: I behold many nations and kingdoms.

And he said unto me: These are the nations and kingdoms of the Gentiles.

And it came to pass that I saw among the nations of the Gentiles the formation of a great church.

And the angel said unto me: Behold the formation of a church which is most abominable above all other churches, which slayeth the saints of God, yea, and tortureth them and bindeth them down, and yoketh them with a yoke of iron, and bringeth them down into captivity.

And it came to pass that I beheld this great and abominable church; and I saw the devil that he was the founder of it.

And I also saw gold, and silver, and silks, and scarlets, and fine-twined linen, and all manner of precious clothing; and I saw many harlots.

And the angel spake unto me, saying: Behold the gold, and the silver, and the silks, and the scarlets, and the fine-twined linen, and the precious clothing, and the harlots, are the desires of this great and abominable church.

And also for the praise of the world do they destroy the saints of God, and bring them down into captivity.

And it came to pass that I looked and beheld many waters; and they divided the Gentiles from the seed of my brethren.

And it came to pass that the angel said unto me: Behold the wrath of God is upon the seed of thy brethren.

- 12 Мөн би харж бас харийнханы дунд буй, их усаар ах нарын маань үр удмаас тусгаарлагдсан нэгэн хүнийг болгоов; мөн би Бурханы Сүнс доош бууж мөн тэр хүний дээр нөлөөлөхийг болгоов; мөн тэрбээр урагшлан их усанд одож, бүр амлагдсан нутагт байсан ах нарын маань үр удамд хүрэв.
- 13 Мөнхүү улиран тохиох дор харийнханы өөр зарим дээр нь Бурханы Сүнс нөлөөлснийг би болгоов; мөн тэд боолчлолоос гарч, их усанд одсон болой.
- 14 Мөнхүү улиран тохиох дор амлалтын нутагт харийнханы олон ард түмэн байхыг би болгоов; мөн Бурханы хилэгнэл ах нарын маань үр удмын дээр байсныг би болгоов; мөн тэд харийнханы өмнө тараагдаж бас бут цохигдсон болой.
- 15 Мөн би Их Эзэний Сүнсийг, тэр нь харийнхан дээр байсныг, мөн тэд дэгжиж өв залган эзэмших нутагтай болсныг болгоов; мөн тэд цагаан байсныг, бас үлэмж хонгор мөн үзэсгэлэн гоо, миний ардын хөнөөгдөхөөсөө өмнө байсантай адил байхыг би болгоов.
- 16 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, боолчлолоос ангижран гарсан харийнхан Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгахыг болгоов; мөн Их Эзэний хүч тэдэнтэй орших буюу.
- 17 Мөн эх нутгийнхан нь болох тэр Харийнхан тэдний эсрэг тулалдахаар усан дээр, түүнчлэн газар дээр ч нэгдэн цугларсан байхыг би болгоов.
- 18 Мөн Бурханы хүч тэдэнтэй оршиж, мөн Бурханы хилэгнэл тэдний эсрэг тулалдахаар нэгдэн цугларах тэд бүгдийн дээр байхыг түүнчлэн би болгоов.
- 19 Мөн би, Нифай, боолчлолоос гарсан харийнхан, Бурханы хүчээр бусад бүх үндэстний гараас чөлөөлөгдөхийг үзэв.
- 20 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэд уг нутагт дэвжсэнийг болгоов, мөн тэдний дунд тараагдсан нэгэн номыг би үзэв.
- 21 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Уг номын учрыг мэдэх үү та? хэмээв.
- 22 Мөн би түүнд хандан: Миний бие мэдэх нь үгүй хэмээв.

And I looked and beheld a man among the Gentiles, who was separated from the seed of my brethren by the many waters; and I beheld the Spirit of God, that it came down and wrought upon the man; and he went forth upon the many waters, even unto the seed of my brethren, who were in the promised land.

And it came to pass that I beheld the Spirit of God, that it wrought upon other Gentiles; and they went forth out of captivity, upon the many waters.

And it came to pass that I beheld many multitudes of the Gentiles upon the land of promise; and I beheld the wrath of God, that it was upon the seed of my brethren; and they were scattered before the Gentiles and were smitten.

And I beheld the Spirit of the Lord, that it was upon the Gentiles, and they did prosper and obtain the land for their inheritance; and I beheld that they were white, and exceedingly fair and beautiful, like unto my people before they were slain.

And it came to pass that I, Nephi, beheld that the Gentiles who had gone forth out of captivity did humble themselves before the Lord; and the power of the Lord was with them.

And I beheld that their mother Gentiles were gathered together upon the waters, and upon the land also, to battle against them.

And I beheld that the power of God was with them, and also that the wrath of God was upon all those that were gathered together against them to battle.

And I, Nephi, beheld that the Gentiles that had gone out of captivity were delivered by the power of God out of the hands of all other nations.

And it came to pass that I, Nephi, beheld that they did prosper in the land; and I beheld a book, and it was carried forth among them.

And the angel said unto me: Knowest thou the meaning of the book?

And I said unto him: I know not.

23 Мөн тэрбээр: Болгоогтун, энэ нь Иудейн амнаас гарсан бөлгөө. Мөн би, Нифай, үүнийг болгоов; мөн тэрээр надад хандан хэлэв: Таны болгоож буй ном нь Их Эзэний Израилын угсаатай хийсэн гэрээг тээсэн иудейчүүдийн цэдэг бөлгөө; мөн энэ нь түүнчлэн ариун бошиглогчдын олон бошиглолыг агуулах буюу; мөн энэ нь гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэдгээртэй адил цэдэг, гэвч тэдгээр нь тийм ч олон биш болой; тийм боловч, тэдгээр нь Израилын угсаатай хийсэн Их Эзэний гэрээнүүдийг агуулдаг; иймийн тул, тэдгээр нь харийнханд агуу их үнэт зүйл билээ.

24 Мөн Их Эзэний сайхь тэнгэр элч надад хандан хэлэв: Та уг ном Иудейн амнаас гарсныг болгоосон буюу; мөн энэ нь Иудейн амнаас гарахдаа арванхоёр төлөөлөгчийн гэрчлэх тэр Их Эзэний сайн мэдээний бүрэн байдлыг агуулж байв; мөн тэд Бурханы Хурганд орших үнэний дагуу гэрчлэх буюу.

25 Иймийн тул, эдгээр зүйлүүд нь Бурханд орших үнэний дагуу иудейчүүдээс одож харийнханд цэврээрээ очих бөлгөө.

26 Мөн тэдгээр нь Хурганы арванхоёр төлөөлөгчийн гараар иудейчүүдээс харийнханд хүргэгдсэний дараа, агуу хийгээд жигшүүрт сүмийн үүслийг, бусад бүх сүмүүдээс хамгийн жигшүүрт түүнийг та үзэж буй бөлгөө; учир нь болгоогтун, тэд Хурганы сайн мэдээнээс олон тодорхой болоод хамгийн эрхэм үнэт хэсгүүдийг зайлуулан авсан; мөн түүнчлэн Их Эзэний олон гэрээг тэд авч зайлуулсан бөлгөө.

27 Мөн тэд энэ бүгдийг үйлдсэн тэд Их Эзэний зөв замуудыг гажуудуулж болохын тулд, тэд хүмүүний үрсийн мэлмийг сохолж бас зүрх сэтгэлийг хатууруулахын тулд болой.

28 Иймийн тул, тэр ном агуу хийгээд жигшүүрт сүмийн гараар дамжсаны дараа, олон тодорхой болоод эрхэм үнэт зүйл Бурханы Хурганы ном болох тэрхүү номноос авч зайлуулагдсаныг та харсан бөлгөө.

And he said: Behold it proceedeth out of the mouth of a Jew. And I, Nephi, beheld it; and he said unto me: The book that thou beholdest is a record of the Jews, which contains the covenants of the Lord, which he hath made unto the house of Israel; and it also containeth many of the prophecies of the holy prophets; and it is a record like unto the engravings which are upon the plates of brass, save there are not so many; nevertheless, they contain the covenants of the Lord, which he hath made unto the house of Israel; wherefore, they are of great worth unto the Gentiles.

And the angel of the Lord said unto me: Thou hast beheld that the book proceeded forth from the mouth of a Jew; and when it proceeded forth from the mouth of a Jew it contained the fulness of the gospel of the Lord, of whom the twelve apostles bear record; and they bear record according to the truth which is in the Lamb of God.

Wherefore, these things go forth from the Jews in purity unto the Gentiles, according to the truth which is in God.

And after they go forth by the hand of the twelve apostles of the Lamb, from the Jews unto the Gentiles, thou seest the formation of that great and abominable church, which is most abominable above all other churches; for behold, they have taken away from the gospel of the Lamb many parts which are plain and most precious; and also many covenants of the Lord have they taken away.

And all this have they done that they might pervert the right ways of the Lord, that they might blind the eyes and harden the hearts of the children of men.

Wherefore, thou seest that after the book hath gone forth through the hands of the great and abominable church, that there are many plain and precious things taken away from the book, which is the book of the Lamb of God.

29 Мөн эдгээр тодорхой болоод эрхэм үнэт зүйлүүд зайлуулагдсаны дараа энэ нь харийнханы бүх үндэстнүүдэд очих болно; мөн, тийм ээ, бүр харийнхан боолчлолоос гарч одоход таны харсан тэр их усыг гатлан энэ нь харийнханы бүх үндэстнүүдэд очсоны дараа—Бурханы Хурган дахь илэрхий байдлын дагуу хүмүүний үрсийн ойлголтонд илэрхий болох, уг номноос зайлуулагдсан, олон тодорхой болоод эрхэм үнэт зүйлүүдийн учир—Хурганы сайн мэдээнээс зайлуулагдан авагдсан эдгээр зүйлүүдийн учир, үлэмж агуу олон нь бүдрэхийг, тийм ээ, үүний хэрээр Сатан тэднийг агуу хүчээр эзэмдэхийг та үзэж буй нь энэ болой.

30 Хэдий тийм ч, боолчлолоос гарч явсан тэр, Их Эзэн Бурхан таны эцэгтэй, түүний үр удам өв залгамжлан эзэмших болно хэмээн гэрээ байгуулсан тэр, мөн нутгийн гадаргуу дээрх бусад бүх нутгуудаас дээгүүр хэмээгдэх сонгомол, тэр нутагт Бурханы хүчээр бүх үндэстнүүдийн дээр өргөмжлөгдсөн харийнхан; иймийн тул, ах нарын тань дунд буй таны үр удмын цусыг бүрмөсөн устгахыг Их Эзэн Бурхан харийнханд үл зөвшөөрөхийг та харж байна.

31 Тэрбээр, харийнхан ах нарын тань үр удмыг устгахыг ч басхүү үл тэвчих бөлгөө.

32 Үүслийг нь таны харсан тэр жигшүүрт сүмээр далдлагдсан тэр Хурганы сайн мэдээний тодорхой болоод эрхэм үнэт хэсгүүдийн учир харийнханы орсон байхыг нь таны харж буй аймшигтай нүдэн байлай байдалд үүрд үлдэхийг ч Их Эзэн Бурхан үл тэвчинэ.

33 Иймийн тул Бурханы Хурга хэлэв: Би харийнханд нигүүлсэнгүй хандахын тулд Израилын угсааны үлдэгдэлд агуу их шүүлтээр зочлох болно.

And after these plain and precious things were taken away it goeth forth unto all the nations of the Gentiles; and after it goeth forth unto all the nations of the Gentiles, yea, even across the many waters which thou hast seen with the Gentiles which have gone forth out of captivity, thou seest—because of the many plain and precious things which have been taken out of the book, which were plain unto the understanding of the children of men, according to the plainness which is in the Lamb of God—because of these things which are taken away out of the gospel of the Lamb, an exceedingly great many do stumble, yea, insomuch that Satan hath great power over them.

Nevertheless, thou beholdest that the Gentiles who have gone forth out of captivity, and have been lifted up by the power of God above all other nations, upon the face of the land which is choice above all other lands, which is the land that the Lord God hath covenanted with thy father that his seed should have for the land of their inheritance; wherefore, thou seest that the Lord God will not suffer that the Gentiles will utterly destroy the mixture of thy seed, which are among thy brethren.

Neither will he suffer that the Gentiles shall destroy the seed of thy brethren.

Neither will the Lord God suffer that the Gentiles shall forever remain in that awful state of blindness, which thou beholdest they are in, because of the plain and most precious parts of the gospel of the Lamb which have been kept back by that abominable church, whose formation thou hast seen.

Wherefore saith the Lamb of God: I will be merciful unto the Gentiles, unto the visiting of the remnant of the house of Israel in great judgment.

34 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний тэнгэр элч надад хэлэв: Болгоогтун, Бурханы Хурга өгүүлсэн нь, намайг Израилын угсааны үлдэгдэлд зочилсны дараа—мөн миний ярьж буй энэ үлдэгдэл нь эцгийн тань үр удмынх юм—иймийн тул, би тэдэнд шүүлтээр зочилж, мөн Харийнханы гараар тэднийг цохьсны дараа, мөн янхан эмсийн эх болсон жигшүүрт сүмээр далдлагдсан, Хурганы сайн мэдээний хамгийн тодорхой болоод эрхэм үнэт хэсгүүдийн нь учир харийнхан үлэмж ихээр бүдэрсний дараа, Хурга өгүүллүүн—тэр өдөр би харийнханд нигүүлсэнгүй хандах болно, үүний хэрээр би тэдэнд өөрийн хүчээр, тодорхой болоод эрхэм үнэтэй байх миний сайн мэдээнээс ихийг авчрах болно хэмээн Хурга хэлэв.

35 Учир нь болгоогтун, Хурга хэлсэн нь: Би өөрийгөө чиний үр удамд үзүүлэх учир, миний тэдэнд тохинуулах, тодорхой болоод эрхэм үнэт олон зүйлийг тэд бичиглэх болно; мөн чиний үр удам, мөн түүнчлэн ах нарын чинь үр удам устгагдан, итгэлгүйдээ бууран доройтсоны дараа, болгоогтун, эдгээр зүйлүүд харийнханд Хурганы хүч болон бэлгээр ирэхийн тул далдлагдах болно.

36 Мөн миний хад болон миний аврал, миний сайн мэдээ тэдгээрт бичиглэгдэх болно гэдгийг Хурга хэллээ.

37 Мөн миний Сионыг байгуулахыг тэр өдөр эрэлхийлэх тэд адислагдсан болой; учир нь, тэдэнд Ариун Сүнсний бэлэг болон хүч байх буюу; мөн хэрэв тэд эцсээ хүртэл тэвчвээс тэд хожмын өдөр өргөмжлөгдөх ажгуу, мөн Хурганы үүрдийн хаант улсад аврагдах болно; мөн амар амгаланг, тийм ээ, агуу их баярт мэдээг зарлах хэн боловч, уулсын дээр тэд хичнээн үзэсгэлэнтэй байх билээ.

38 Мөнхүү улиран тохиох дор би ах нарынхаа үр удмын үлдэгдлийг, мөн түүнчлэн Иудейн амнаас гарч ирсэн Бурханы Хурганы номыг, тэр нь харийнханаас ах нарын маань үр удмын үлдэгдэлд хүрч ирснийг болгоов.

And it came to pass that the angel of the Lord spake unto me, saying: Behold, saith the Lamb of God, after I have visited the remnant of the house of Israel—and this remnant of whom I speak is the seed of thy father—wherefore, after I have visited them in judgment, and smitten them by the hand of the Gentiles, and after the Gentiles do stumble exceedingly, because of the most plain and precious parts of the gospel of the Lamb which have been kept back by that abominable church, which is the mother of harlots, saith the Lamb—I will be merciful unto the Gentiles in that day, insomuch that I will bring forth unto them, in mine own power, much of my gospel, which shall be plain and precious, saith the Lamb.

For, behold, saith the Lamb: I will manifest myself unto thy seed, that they shall write many things which I shall minister unto them, which shall be plain and precious; and after thy seed shall be destroyed, and dwindle in unbelief, and also the seed of thy brethren, behold, these things shall be hid up, to come forth unto the Gentiles, by the gift and power of the Lamb.

And in them shall be written my gospel, saith the Lamb, and my rock and my salvation.

And blessed are they who shall seek to bring forth my Zion at that day, for they shall have the gift and the power of the Holy Ghost; and if they endure unto the end they shall be lifted up at the last day, and shall be saved in the everlasting kingdom of the Lamb; and whoso shall publish peace, yea, tidings of great joy, how beautiful upon the mountains shall they be.

And it came to pass that I beheld the remnant of the seed of my brethren, and also the book of the Lamb of God, which had proceeded forth from the mouth of the Jew, that it came forth from the Gentiles unto the remnant of the seed of my brethren.

39 Мөн энэ нь тэдэнд ирсний дараа, харийнханаас тэдэнд Хурганы хүчээр ирсэн, харийнхан болон ах нарын маань үр удмын үлдэгдэлд, мөн түүнчлэн газрын гадаргуугаар нэг тархсан байсан иудейчүүдэд бошиглогчдын мөн Хурганы арванхоёр төлөөлөгчийн цэдгүүд үнэн гэдэгт итгүүлэх бусад номуудыг би болгоов.

40 Мөн тэнгэр элч надад хандан ярьж, хэлсэн нь: Таны харийнханы дунд харсан тэр хожмын цэдгүүд, Хурганы арванхоёр төлөөлөгчийнх болох эхний цэдгүүдийн үнэнийг тогтоож, мөн эднээс авагдан зайлуулагдсан тэдгээр тодорхой болоод эрхэм үнэт зүйлсийг мэдүүлэх бөлгөө; мөн бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүст Бурханы Хурга бол Мөнхийн Эцэгийн Хүү хийгээд дэлхийн Аврагч; мөн бүх хүмүүн түүнд ирэх ёстой, эс бөгөөс тэд аврагдаж чадахгүй гэдгийг мэдүүлэх болно.

41 Мөн тэд Хурганы амаар тогтоогдох үгсийн дагуу ирэх ёстой; мөн Хурганы үгс таны үр удмын цэдгүүдэд Хурганы арванхоёр төлөөлөгчийн цэдгийн нэгэн адилаар мэдүүлэгдэх бөлгөө; иймийн тул тэд хоёул нэгдмэл байдлаар бүтээгдэх болно; учир нь бүх дэлхий даяар нэг Бурхан мөн нэг Хоньчин буй.

42 Мөн тэрбээр бүх үндэстэнд, иудейчүүдэд мөн түүнчлэн харийнханд аль алинд нь өөрийгөө үзүүлэх тэр цаг ирэх болно; мөн тэрээр иудейчүүдэд түүнчлэн харийнханд өөрийгөө үзүүлсний дараа, тэгээд тэрээр харийнханд түүнчлэн иудейчүүдэд өөрийгөө үзүүлэх болно, мөн эцсийнх нь эхэнд, мөн эхнийх нь эцэст байх болно.

And after it had come forth unto them I beheld other books, which came forth by the power of the Lamb, from the Gentiles unto them, unto the convincing of the Gentiles and the remnant of the seed of my brethren, and also the Jews who were scattered upon all the face of the earth, that the records of the prophets and of the twelve apostles of the Lamb are true.

And the angel spake unto me, saying: These last records, which thou hast seen among the Gentiles, shall establish the truth of the first, which are of the twelve apostles of the Lamb, and shall make known the plain and precious things which have been taken away from them; and shall make known to all kindreds, tongues, and people, that the Lamb of God is the Son of the Eternal Father, and the Savior of the world; and that all men must come unto him, or they cannot be saved.

And they must come according to the words which shall be established by the mouth of the Lamb; and the words of the Lamb shall be made known in the records of thy seed, as well as in the records of the twelve apostles of the Lamb; wherefore they both shall be established in one; for there is one God and one Shepherd over all the earth.

And the time cometh that he shall manifest himself unto all nations, both unto the Jews and also unto the Gentiles; and after he has manifested himself unto the Jews and also unto the Gentiles, then he shall manifest himself unto the Gentiles and also unto the Jews, and the last shall be first, and the first shall be last.

## 1 Нифай 14

- 1 Мөнхүү улиран тохиох дор, тэдний тээглэх чулууг зайлуулан өөрийгөө үгээр, мөн түүнчлэн хүчээр, чухамхүү үйлэнд үзүүлэх тэр өдөр, хэрэв харийнхан Бурханы Хургыг сонсох аваас—
- 2 Мөн Бурханы Хурганы эсрэг зүрх сэтгэлээ үл хатууруулах аваас, тэд таны эцгийн үр удмын дунд тоологдох болно; тийм ээ, тэд Израилын угсааныхны дунд тоологдох болно; мөн тэд амлагдсан нутагт үүрд адислагдсан хүмүүс байх болно; тэд дахин хэзээ ч боолчлолд хүргэгдэхгүй; мөн Израилын угсаа дахин хэзээ ч сарниулагдахгүй.
- 3 Мөн тэр хүмүүний сүнсийг доош тамд удирдаж болохын тулд, чөтгөр болон түүний хүүхдүүдээр үндэслэгдсэн, агуу хийгээд жигшүүрт сүмээр тэдэнд зориулагдан ухагдсан тэр агуу нүх—тийм ээ, хүмүүний устгалын тулд ухагдсан тэр агуу нүх нь түүнийг ухсан тэднээрээ дүүргэгдэх болно, тэдний бүрмөсөн устгалыг хүртэл хэмээн Бурханы Хурга хэлдэг; төгсгөл үгүй тамд орхигдохоос бусдаар бодгаль устгагдах нь үгүй болой.
- 4 Учир нь болгоогтун, энэ нь чөтгөрийн боолчлолын дагуу, мөн түүнчлэн түүний өмнө ёсон бусыг болон жигшүүрт хэргийг үйлдэх тэд бүгдийн дээрх Бурханы шударга ёсны дагуу буюу.
- 5 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч, Нифай, надад хандаж, хэлсэн нь: Хэрэв харийнхан наманчлах аваас тэдэнд сайн болохыг та болгоосон билээ; мөн түүнчлэн Израилын угсаан дахь Их Эзэний гэрээнүүдийн тухай та мэдэх бөлгөө; мөн түүнчлэн наманчлаагүй хэн боловч эрсдэх ёстойг та сонссон билээ.
- 6 Тиймийн тул, хэрэв тэд Бурханы Хурганы эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах аваас харийнханд халаг тохиох буюу.

## 1 Nephi 14

And it shall come to pass, that if the Gentiles shall hearken unto the Lamb of God in that day that he shall manifest himself unto them in word, and also in power, in very deed, unto the taking away of their stumbling blocks—

And harden not their hearts against the Lamb of God, they shall be numbered among the seed of thy father; yea, they shall be numbered among the house of Israel; and they shall be a blessed people upon the promised land forever; they shall be no more brought down into captivity; and the house of Israel shall no more be confounded.

And that great pit, which hath been digged for them by that great and abominable church, which was founded by the devil and his children, that he might lead away the souls of men down to hell—yea, that great pit which hath been digged for the destruction of men shall be filled by those who digged it, unto their utter destruction, saith the Lamb of God; not the destruction of the soul, save it be the casting of it into that hell which hath no end.

For behold, this is according to the captivity of the devil, and also according to the justice of God, upon all those who will work wickedness and abomination before him.

And it came to pass that the angel spake unto me, Nephi, saying: Thou hast beheld that if the Gentiles repent it shall be well with them; and thou also knowest concerning the covenants of the Lord unto the house of Israel; and thou also hast heard that whoso repenteth not must perish.

Therefore, wo be unto the Gentiles if it so be that they harden their hearts against the Lamb of God.

- 7 Ийнхүү би хүмүүний үрсийн дунд агуу хийгээд гайхамшигт үйлийг үйлдэх цаг ирэх болно хэмээн Бурханы Хурга хэлэв; аль аль талд байх үүрдийнх болох тэрхүү үйл буюу, нэг талаас тэд энх амгалан болон мөнх амьдралд ороход үнэмших, эсвээс тэдний зүрх сэтгэлийн хатуу мөн санаа бодлын харалган байдалдаа орхигдсоноос миний өгүүлсэнчлэн, биеэрээ болон оюун санаагаараа ч чөтгөрийн боолчлолын дагуу доош боолчлолд, мөн түүнчлэн устгалд авчрагдах болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор уг тэнгэр элч эдгээр үгсийг ярьсны дараа, тэрбээр надад хандан: Израилын угсааныхантай хийсэн Эцэгийн гэрээг та санаж байна уу? хэмээв, би түүнд хандан, тийм ээ гэв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр надад хандан: Харагтун, мөн жигшүүрт хэргүүдийн эх, үндэслэгч нь чөтгөр болох тэр агуу хийгээд жигшүүрт сүмийг болгоогтун хэмээв.
- 10 Мөн тэрээр надад хандан: Зөвхөн хоёр сүм буйг болгоогтун; нэг нь Бурханы Хурганы сүм, мөн нөгөө нь чөтгөрийн сүм бөлгөө; иймийн тул, Бурханы Хурганы сүмд эс харьяалагдах хэн боловч жигшүүрт хэргүүдийн эх болох агуу сүмд харьяалагдана, мөн тэр нь бүх дэлхийн садар эм билээ.
- 11 Мөнхүү улиран тохиох дор би харж бас бүх дэлхийн садар эмийг мөн тэрээр их усан дээр суусныг болгоов: мөн тэр нь бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсийн дунд, бүх дэлхийг эзэгнэх бөлгөө.
- 12 Мөнхүү улиран тохиох дор би Бурханы Хурганы сүмийг болгоов, мөн энэ нь их усан дээр суугч садар эмийн тэрхүү ёсон бус хийгээд жигшүүрт хэргүүдийн учир, тоогоороо цөөн байв; хэдий тийм, Бурханы гэгээнтнүүд байсан Хурганы сүмийнхэн түүнчлэн бүх дэлхийн гадаргуугаар оршин байхыг би болгоов; мөн тэдний эзэмшил нь газрын гадаргуугаар бага байв, миний харсан тэр агуу садар эмийн ёсон бусын учир болой.
- 13 Мөнхүү улиран тохиох дор жигшүүрт үйлсийн агуу эх, харийнханы бүх улсуудын дундаас олон ардыг Бурханы Хурганы эсрэг тулалдуулахаар бүх газрын гадаргууд нэгтгэн цуглуулахыг би болгоов.

For the time cometh, saith the Lamb of God, that I will work a great and a marvelous work among the children of men; a work which shall be everlasting, either on the one hand or on the other—either to the convincing of them unto peace and life eternal, or unto the deliverance of them to the hardness of their hearts and the blindness of their minds unto their being brought down into captivity, and also into destruction, both temporally and spiritually, according to the captivity of the devil, of which I have spoken.

And it came to pass that when the angel had spoken these words, he said unto me: Rememberest thou the covenants of the Father unto the house of Israel? I said unto him, Yea.

And it came to pass that he said unto me: Look, and behold that great and abominable church, which is the mother of abominations, whose founder is the devil.

And he said unto me: Behold there are save two churches only; the one is the church of the Lamb of God, and the other is the church of the devil; wherefore, whoso belongeth not to the church of the Lamb of God belongeth to that great church, which is the mother of abominations; and she is the whore of all the earth.

And it came to pass that I looked and beheld the whore of all the earth, and she sat upon many waters; and she had dominion over all the earth, among all nations, kindreds, tongues, and people.

And it came to pass that I beheld the church of the Lamb of God, and its numbers were few, because of the wickedness and abominations of the whore who sat upon many waters; nevertheless, I beheld that the church of the Lamb, who were the saints of God, were also upon all the face of the earth; and their dominions upon the face of the earth were small, because of the wickedness of the great whore whom I saw.

And it came to pass that I beheld that the great mother of abominations did gather together multitudes upon the face of all the earth, among all the nations of the Gentiles, to fight against the Lamb of God.



14 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Хурганы сүмийн гэгээнтнүүдийн дээр, мөн газрын гадаргуугаар нэг тархсан Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буух Бурханы Хурганы хүчийг болгоов; мөн тэд ялгуусан алдар суунд зөв шударга байдал хийгээд Бурханы хүчээр зэвсэглэсэн байв.

15 Мөнхүү улиран тохиох дор Бурханы хилэн агуу хийгээд жигшүүрт сүмийн дээр цутгагдан, үүний хэрээр дэлхийн бүх үндэстэн ястнуудын дунд дайнууд болон дайны цуурхлууд байсныг би болгоов.

16 Мөн дайн тулалдаан хийгээд дайны цуурхлууд жигшүүрт хэргүүдийн эхийн эзэгнэх бүх үндэстнүүдийн дунд эхлэхэд, сайхь тэнгэр элч надад хандаж, хэлрүүн: Болгоогтун, Бурханы хилэн янхан эмсийн эх дээр буй; мөн болгоогтун, та эдгээр бүх зүйлийг харж буй—

17 Мөн бүх дэлхийн агуу хийгээд жигшүүрт сүм, түүний үндэслэгч нь чөтгөр болох, садар эмсийн эх дээр Бурханы хилэн цутгагдах тэрхүү өдөр ирэхэд, чухам тэр өдөр, Израилын угсааны хүмүүстэй түүний хийсэн тэр гэрээнүүд биелэгдэх зам бэлтгэгдэж, Эцэгийн ажил эхлэх болно.

18 Мөнхүү улиран тохиох дор сайхь тэнгэр элч надад хандан ярьж, өгүүлрүүн: Харатун! хэмээв.

19 Мөн би харж бас нэгэн хүнийг, мөн тэрээр цагаан орхимж өмссөнийг болгоов.

20 Мөн сайхь тэнгэр элч надад хандан: Хурганы арванхоёр төлөөлөгчийн нэгийг болгоогтун хэмээв.

21 Болгоогтун, тэрээр эдгээр зүйлүүдийн үлдсэнийг харж бас бичиглэх болно; тийм ээ, мөн түүнчлэн тохион байсан олон зүйлийг.

22 Мөн түүнчлэн тэрээр дэлхийн төгсгөлийн талаар бичих болно.

23 Иймийн тул, түүний бичих зүйлүүд шударга бөгөөд үнэн бөлгөө; мөн болгоогтун, тэдгээр нь Иудейн амнаас үүсэхийг нь таны болгоосон тэр номонд бичиглэгдэнэ; мөн тэд Иудейн амнаас үүссэн тэр цагт, өөрөөр хэлбэл, уг ном Иудейн амнаас үүссэн тэр цагт, бичиглэгдсэн тэр зүйлүүд нь тодорхой болоод нандин бас эрхэм үнэт, мөн бүх хүмүүнд ойлгоход хялбар байв.

And it came to pass that I, Nephi, beheld the power of the Lamb of God, that it descended upon the saints of the church of the Lamb, and upon the covenant people of the Lord, who were scattered upon all the face of the earth; and they were armed with righteousness and with the power of God in great glory.

And it came to pass that I beheld that the wrath of God was poured out upon that great and abominable church, insomuch that there were wars and rumors of wars among all the nations and kindreds of the earth.

And as there began to be wars and rumors of wars among all the nations which belonged to the mother of abominations, the angel spake unto me, saying: Behold, the wrath of God is upon the mother of harlots; and behold, thou seest all these things—

And when the day cometh that the wrath of God is poured out upon the mother of harlots, which is the great and abominable church of all the earth, whose founder is the devil, then, at that day, the work of the Father shall commence, in preparing the way for the fulfilling of his covenants, which he hath made to his people who are of the house of Israel.

And it came to pass that the angel spake unto me, saying: Look!

And I looked and beheld a man, and he was dressed in a white robe.

And the angel said unto me: Behold one of the twelve apostles of the Lamb.

Behold, he shall see and write the remainder of these things; yea, and also many things which have been.

And he shall also write concerning the end of the world.

Wherefore, the things which he shall write are just and true; and behold they are written in the book which thou beheld proceeding out of the mouth of the Jew; and at the time they proceeded out of the mouth of the Jew, or, at the time the book proceeded out of the mouth of the Jew, the things which were written were plain and pure, and most precious and easy to the understanding of all men.

- 24 Мөн болгоогтун, Хурганы энэ төлөөлөгчийн бичиглэх зүйлүүд нь таны харсан олон зүйл байх бөлгөө; мөн болгоогтун, үлдсэнийг нь та харах болно.
- 25 Гэвч үүнээс хожим таны үзэх зүйлийг та бичихгүй; учир нь тэдгээрийг тэр бичвэл зохино хэмээн Бурханы Хурганы төлөөлөгчийг Их Эзэн Бурхан томилсон бөлгөө.
- 26 Мөн түүнчлэн байсан тэдэнд бусад бүх зүйлийг тэрээр үзүүлж, мөн тэд тэдгээрийг бичих буюу; мөн тэдгээр нь Хурган дахь үнэний дагуу Израилын угсаанд Их Эзэнээс зохих цагтаа эрхэм нандин байдлаараа уламжлагдан ирэхийн тул лацдагдсан болно.
- 27 Мөн би, Нифай, тэнгэр элчийн хэлсэнчлэн, Хурганы төлөөлөгчийн нэр Иохан гэдгийг сонссон бөгөөд ийн гэрчлэх бөлгөө.
- 28 Мөн болгоогтун, би, Нифай, өөрийн үзсэн болоод сонссон зүйлүүдийн үлдэгдлийг бичих нь надад хориглогдсон билээ; иймийн тул миний бичсэн зүйлүүд надад хангалттай; мөн би үзсэн зүйлүүдээсээ зөвхөн багахан хэсгийг бичиглэсэн ажгуу.
- 29 Мөн би эцгийнхээ харсан зүйлийг харсан бөгөөд, мөн Их Эзэний тэнгэр элч тэдгээрийг надад мэдүүлсэн хэмээн би гэрчлэх бөлгөө.
- 30 Мөн эдүгээ би Сүнсэнд автагдсан үедээ харсан тэдгээр зүйлүүдийн талаар ярихаа төгсгөл болгоё; мөн миний харсан бүх зүйл бичигдээгүй хэдий ч, миний бичсэн зүйлүүд үнэн бөлгөө. Мөн энэ нь ийм болой. Амен.

And behold, the things which this apostle of the Lamb shall write are many things which thou hast seen; and behold, the remainder shalt thou see.

But the things which thou shalt see hereafter thou shalt not write; for the Lord God hath ordained the apostle of the Lamb of God that he should write them.

And also others who have been, to them hath he shown all things, and they have written them; and they are sealed up to come forth in their purity, according to the truth which is in the Lamb, in the own due time of the Lord, unto the house of Israel.

And I, Nephi, heard and bear record, that the name of the apostle of the Lamb was John, according to the word of the angel.

And behold, I, Nephi, am forbidden that I should write the remainder of the things which I saw and heard; wherefore the things which I have written suffice me; and I have written but a small part of the things which I saw.

And I bear record that I saw the things which my father saw, and the angel of the Lord did make them known unto me.

And now I make an end of speaking concerning the things which I saw while I was carried away in the Spirit; and if all the things which I saw are not written, the things which I have written are true. And thus it is. Amen.

## 1 Нифай 15

- 1 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, сүнсэнд автагдан байж, мөн эдгээр бүх зүйлийг үзсэний дараа эцгийнхээ майханд эргэж ирэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор би ах нараа харав, мөн тэд миний эцгийн тэдэнд ярьсан зүйлүүдийн талаар өөр хоорондоо маргалдаж байв.
- 3 Учир нь Их Эзэнээс эс асуух аваас хүмүүн ойлгоход бэрх олон агуу зүйлийг тэдэнд тэрбээр үнэнээр ярив; мөн тэд зүрх сэтгэлдээ хатуурхсаны учир, тиймийн тул тэд Их Эзэнд зохих ёсоор найдсан нь үгүй.
- 4 Мөн эдүгээ би, Нифай, тэдний зүрх сэтгэл хатуугийн учир, мөн түүнчлэн, өөрийн үзсэн зүйлүүдийн, мөн хүмүүний үрсийн агуу ёсон бусын тул тэдгээр нь зайлшгүй улиран тохиох ёстойг мэдсэний учир гашуудан байсан бөлгөө.
- 5 Мөнхүү улиран тохиох дор зовлонгийнхоо учир би гунигт дарагдан байв, миний хүмүүсийн устгалын учир, миний зовлон бүхнээс илүү их хэмээн би ойлгож байлаа, учир нь би тэдний уналтыг харсан.
- 6 Мөнхүү улиран тохиох дор би хүчийг хүлээн авсны дараа ах нартаа хандан ярьж, тэдний зөрчилдөөний шалтгааныг мэдэхийг тэднээс хүсэв.
- 7 Мөн тэд: Болгоогтун, эцгийнхээ чидун модны унаган мөчрүүдийн талаар, мөн түүнчлэн харийнханы талаар ярьсан үгсийг бид ойлгож чадахгүй байна хэмээв.
- 8 Мөн би тэдэнд хандан: Та нар Их Эзэнээс лавласан уу? хэмээв.
- 9 Мөн тэд надад хэлэв: Бид тэгсэнгүй; учир нь Их Эзэн тийм ямар ч зүйлийг бидэнд мэдүүлсэн нь үгүй.
- 10 Болгоогтун, би тэдэнд хандан: Та нар яахан Их Эзэний зарлигийг эс дагах билээ? Зүрх сэтгэл тань хатуугийн учир та нар яагаад эрсдэх билээ? хэмээв.
- 11 Их Эзэний хэлсэн зүйлийг та нар үл санана гэж үү?—Хэрэв та нар зүрх сэтгэлээ үл хатууруулан, миний зарлигуудыг дагахад хичээнгүйлэн, мөн та нар хүлээн авна гэдэгтээ найдсаар, мөн надаас итгэлтэйгээр асуух аваас, эдгээр зүйлүүд та нарт лавтайяа мэдүүлэгдэх болно.

## 1 Nephi 15

And it came to pass that after I, Nephi, had been carried away in the Spirit, and seen all these things, I returned to the tent of my father.

And it came to pass that I beheld my brethren, and they were disputing one with another concerning the things which my father had spoken unto them.

For he truly spake many great things unto them, which were hard to be understood, save a man should inquire of the Lord; and they being hard in their hearts, therefore they did not look unto the Lord as they ought.

And now I, Nephi, was grieved because of the hardness of their hearts, and also, because of the things which I had seen, and knew they must unavoidably come to pass because of the great wickedness of the children of men.

And it came to pass that I was overcome because of my afflictions, for I considered that mine afflictions were great above all, because of the destruction of my people, for I had beheld their fall.

And it came to pass that after I had received strength I spake unto my brethren, desiring to know of them the cause of their disputations.

And they said: Behold, we cannot understand the words which our father hath spoken concerning the natural branches of the olive tree, and also concerning the Gentiles.

And I said unto them: Have ye inquired of the Lord?

And they said unto me: We have not; for the Lord maketh no such thing known unto us.

Behold, I said unto them: How is it that ye do not keep the commandments of the Lord? How is it that ye will perish, because of the hardness of your hearts?

Do ye not remember the things which the Lord hath said?—If ye will not harden your hearts, and ask me in faith, believing that ye shall receive, with diligence in keeping my commandments, surely these things shall be made known unto you.

12 Болгоогтун, бидний эцэгт байсан Их Эзэний сүн-  
сээр Израилын угсаа чидуны модтой зүйрлэгдсэ-  
нийг би та нарт хэлж байна; мөн болгоогтун, бид  
Израилын угсаанаас тасарч салгагдаагүй бил үү, мөн  
бид Израилын угсааны мөчир биш бил үү

13 Мөн эдүгээ, харийнханы бүрэн байдлаар унаган  
мөчрүүд нь залгагдах талаар бидний эцгийн өгүүл-  
сэн нь, бидний үр удам итгэлгүйдээ доройтсон байх  
болно, тийм ээ, олон жилийн турш, мөн Мессиа өө-  
рийгөө хүмүүний үрсэд биеэр үзүүлснээс олон  
үеийн дараа, тэр хожмын өдрүүдэд, тэгээд  
Мессиагийн сайн мэдээний бүрэн байдал харийн-  
ханд, мөн харийнхнаас бидний үр удмын үлдэгдэлд  
ирэх болно гэсэн утгатай—

14 Мөн тэр өдөр бидний үр удмын үлдэгдэл, тэд бол  
Израилын угсааных гэдгээ, мөн тэд Их Эзэнтэй гэр-  
рээт хүмүүс гэдгээ мэдэх болно; мөн тэгээд тэд өвөг  
дээдсийнхээ мэдлэгт мөн түүнчлэн эцэг өвгөд нь  
түүгээр тохинуулагдсан өөрсдийн Гэтэлгэгчийн сайн  
мэдээний тухай мэдлэгт ирж мөн мэдэх болно; ий-  
мийн тул тэд өөрсдийн Гэтэлгэгч мөн түүний сургаа-  
лын мөн чанарын мэдлэгт орох болно; тэд түүнд хэр-  
хэн ирж бас аврагдахыг мэдэж болохын тулд буюу.

15 Мөн тэгээд тэр өдөр тэд баярлаж мөн өөрсдийн  
хад болон аврал болох, өөрсдийн үүрдийн Бурханыг  
магтахгүй гэж үү? Тийм ээ, тэр өдөр, тэд жинхэнэ  
усан үзмийн модноос хүч чадал мөн шим тэжээл хү-  
лээн авахгүй гэж үү? Тийм ээ, тэд Бурханы жинхэнэ  
сүрэгт нийлэхгүй бус уу

16 Болгоогтун, би та нарт хэлье, Тийм ээ; тэд  
Израилын угсааныхны дунд дахин санагдах болно;  
чидун модны унаган мөчрүүд учраас, жинхэнэ чиду-  
ны модонд тэд залгагдах болно.

17 Мөн эцгийн маань дурдсан нь ийм утгатай болой;  
мөн тэрээр энэ нь тэд харийнханаар тарагдсанаас  
хойш тэр болтол улиран тохиохгүйг дурдсан бөлгөө;  
мөн энэ нь харийнханы тусламжтайгаар ирэхийг  
дээр дурдсан, чухамдаа иудейчүүдээр өөрөөр хэл-  
бэл, Израилын угсааныхнаар эсэргүүцэгдэх чухам  
тэрхүү шалтгааны улмаас Их Эзэн өөрийн хүчийг  
харийнханд үзүүлж болохын тулд болой.

Behold, I say unto you, that the house of Israel was  
compared unto an olive tree, by the Spirit of the Lord  
which was in our father; and behold are we not broken  
off from the house of Israel, and are we not a branch of  
the house of Israel?

And now, the thing which our father meaneth con-  
cerning the grafting in of the natural branches through  
the fulness of the Gentiles, is, that in the latter days,  
when our seed shall have dwindled in unbelief, yea, for  
the space of many years, and many generations after the  
Messiah shall be manifested in body unto the children  
of men, then shall the fulness of the gospel of the  
Messiah come unto the Gentiles, and from the Gentiles  
unto the remnant of our seed—

And at that day shall the remnant of our seed know  
that they are of the house of Israel, and that they are the  
covenant people of the Lord; and then shall they know  
and come to the knowledge of their forefathers, and  
also to the knowledge of the gospel of their Redeemer,  
which was ministered unto their fathers by him; where-  
fore, they shall come to the knowledge of their  
Redeemer and the very points of his doctrine, that they  
may know how to come unto him and be saved.

And then at that day will they not rejoice and give  
praise unto their everlasting God, their rock and their  
salvation? Yea, at that day, will they not receive the  
strength and nourishment from the true vine? Yea, will  
they not come unto the true fold of God?

Behold, I say unto you, Yea; they shall be remem-  
bered again among the house of Israel; they shall be  
grafted in, being a natural branch of the olive tree, into  
the true olive tree.

And this is what our father meaneth; and he  
meaneth that it will not come to pass until after they are  
scattered by the Gentiles; and he meaneth that it shall  
come by way of the Gentiles, that the Lord may show  
his power unto the Gentiles, for the very cause that he  
shall be rejected of the Jews, or of the house of Israel.

- 18 Иймийн тул, бидний эцэг зөвхөн бидний үр удмын тухай бус, харин эцсийн өдрүүдэд биелэгдэх ёстой гэрээг дурдан, бүх Израилын угсааны тухай түүнчлэн ярьсан бөлгөө; Их Эзэнээс бидний эцэг Абрахамтай хийсэн, чиний үр удмаар газар дэлхийн бүх үндэстэн адислагдах болно хэмээн өгүүлэх тэрхүү гэрээ буюу.
- 19 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэдэнд хандан эдгээр зүйлүүдийн талаар ихийг ярив; тийм ээ, хожмын өдрүүд дэх иудейчүүдийн сэргээлтийн талаар би тэдэнд ярьсан болой.
- 20 Мөн би тэдэнд Израилын угсааны, өөрөөр хэлбэл иудейчүүдийн сэргээлтийн талаар ярьсан Исаиагийн үгсийг тоочив; мөн тэд сэргээгдсэнийхээ дараа дахин бусниулагдахгүй, бас дахин тараагдах ч үгүй. Мөнхүү улиран тохиох дор би ах нартаа хандан олон үгсийг ярив, иймээс тэд тайтгарлыг олж мөн Их Эзэний өмнө өөрсдийгөө даруу төлөв болгов.
- 21 Мөнхүү улиран тохиох дор тэд надад хандан дахин ярьж, хэлсэн нь: Бидний эцгийн үзсэн зүүдэн дэх энэ зүйл ямар утгатай билээ? Түүний харсан тэр мод ямар утгатай билээ? гэв.
- 22 Мөн би тэдэнд хандан энэ нь амьдралын модыг төлөөлсөн бөлгөө хэмээв.
- 23 Мөн тэд надад хандан: бидний эцгийн үзсэн, уг модны зүг удирдсан тэр төмөр бариул ямар утгатай вэ? хэмээв.
- 24 Мөн би тэдэнд хандан энэ нь Бурханы үг байсныг хэлэв; мөн Бурханы үгийг анхааран сонсох, мөн үүнээс зууран барих хэн боловч, тэд хэзээ ч эрсдэх нь үгүй; бас хортны уруу таталтууд хийгээд галт сумнууд, тэднийг устгал уруу удирдахаар тэднийг харалган болгож давамгайлах нь ч үгүй.
- 25 Иймийн тул, би, Нифай, Их Эзэний үгэнд анхаарал тавихыг тэдэнд ухуулав; тийм ээ, Бурханы үгэнд анхаарал тавин мөн түүний зарлигуудыг бүх зүйл дээр үргэлж дагахыг сана хэмээн өөрийн бодгалийн бүх эрч хүчээр мөн өөрт буй бүх чадавхиараа тэдэнд ухуулсан бөлгөө.
- 26 Мөн тэд надад хандан: бидний эцгийн харсан уст голын утга юун билээ? хэмээв.

Wherefore, our father hath not spoken of our seed alone, but also of all the house of Israel, pointing to the covenant which should be fulfilled in the latter days; which covenant the Lord made to our father Abraham, saying: In thy seed shall all the kindreds of the earth be blessed.

And it came to pass that I, Nephi, spake much unto them concerning these things; yea, I spake unto them concerning the restoration of the Jews in the latter days.

And I did rehearse unto them the words of Isaiah, who spake concerning the restoration of the Jews, or of the house of Israel; and after they were restored they should no more be confounded, neither should they be scattered again. And it came to pass that I did speak many words unto my brethren, that they were pacified and did humble themselves before the Lord.

And it came to pass that they did speak unto me again, saying: What meaneth this thing which our father saw in a dream? What meaneth the tree which he saw?

And I said unto them: It was a representation of the tree of life.

And they said unto me: What meaneth the rod of iron which our father saw, that led to the tree?

And I said unto them that it was the word of God; and whoso would hearken unto the word of God, and would hold fast unto it, they would never perish; neither could the temptations and the fiery darts of the adversary overpower them unto blindness, to lead them away to destruction.

Wherefore, I, Nephi, did exhort them to give heed unto the word of the Lord; yea, I did exhort them with all the energies of my soul, and with all the faculty which I possessed, that they would give heed to the word of God and remember to keep his commandments always in all things.

And they said unto me: What meaneth the river of water which our father saw?

- 27 Мөн би тэдэнд хандан эцгийн минь харсан тэр ус бол бузар байдал хэмээв; мөн түүний оюун өөр зүйлүүдэд хандсан байсны улмаас тэр усны бузрыг эс болгоосон буюу.
- 28 Мөн би тэдэнд хандан энэ нь аймшигт ангал, амьдралын модноос мөн түүнчлэн Бурханы гэгээнтнүүдээс ёс бусыг үйлдэгчдийг зааглах тэр аймшигт ангал байсан бөлгөө.
- 29 Мөн би тэдэнд хандан энэ нь ёс бусыг үйлдэгсдэд бэлтгэгдсэн болохыг сайхь тэнгэр элч надад хэлсэн тэрхүү, аймшигт тамын дүрслэл байсан хэмээв.
- 30 Мөн би тэдэнд хандан, бидний эцэг түүнчлэн Бурханы шударга ёс нь ёс бусыг үйлдэгсдийг зөв шударгыг үйлдэгсдээс түүнчлэн зааглан хуваасныг харсан бөлгөө; мөн түүний гялалзах нь Бурханд үүрд болон үргэлж, мөн төгсөлгүйгээр дүрэлзэх галын гялалзах лугаа адил байсныг хэлсэн бөлгөө.
- 31 Мөн тэд надад хандан: энэ зүйл сорилтын өдрүүдэд биеийн зовлонг илтгэх эсвээс, цаг зуурын махбодийг үхсэний дараа сүнсний эцсийн байдлыг илтгэх буюу, эсвээс цаг зуурын зүйлийг хэлж байгаа юм уу? хэмээв.
- 32 Мөнхүү улиран тохиох дор би тэдэнд хандан энэ нь биеийн болон оюун санааны зүйлүүдийн аль алиныг нь төлөөлж байсныг хэлэв; учир нь тэд өөрсдийн үйлсээр шүүгдэх ёстой тэрхүү өдөр ирнэ, тийм ээ, бүр зуурдын бие махбодиор тэдний сорилтын өдрүүдэд үйлдэгдсэн тэрхүү үйлсээр буюу.
- 33 Иймийн тул, хэрэв тэд өөрсдийн ёс бус үйлэнд насыг юүлбээс тэд түүнчлэн зөв шударгад хамаарагдах оюун санааны тэр зүйлүүдийн хувьд зайлуулагдах ёстой; иймийн тул, тэд өөрсдийн үйлсээр шүүгдэхийн учир Бурханы өмнө зогсохоор авчрагдах ёстой; мөн хэрэв тэдний үйлс бузар байсан аваас тэд ч бузар байх ёстой нь зайлшгүй; мөн хэрэв тэд бузар аваас тэд Бурханы хаант улсад оршиж чадахгүй байх нь гарцаагүй; хэрэв ингэвээс, Бурханы хаант улс түүнчлэн бузар байх ёстой.
- 34 Гэвч болгоогтун, би та нарт хэлье, Бурханы хаант улс бол бузар бус, мөн өчүүхэн ч цэвэр бус зүйл Бурханы хаант улсад орж чадахгүй; иймийн тул бузар гэгдэх түүнд бэлтгэгдсэн бузар байр байх л ёстой.

And I said unto them that the water which my father saw was filthiness; and so much was his mind swallowed up in other things that he beheld not the filthiness of the water.

And I said unto them that it was an awful gulf, which separated the wicked from the tree of life, and also from the saints of God.

And I said unto them that it was a representation of that awful hell, which the angel said unto me was prepared for the wicked.

And I said unto them that our father also saw that the justice of God did also divide the wicked from the righteous; and the brightness thereof was like unto the brightness of a flaming fire, which ascendeth up unto God forever and ever, and hath no end.

And they said unto me: Doth this thing mean the torment of the body in the days of probation, or doth it mean the final state of the soul after the death of the temporal body, or doth it speak of the things which are temporal?

And it came to pass that I said unto them that it was a representation of things both temporal and spiritual; for the day should come that they must be judged of their works, yea, even the works which were done by the temporal body in their days of probation.

Wherefore, if they should die in their wickedness they must be cast off also, as to the things which are spiritual, which are pertaining to righteousness; wherefore, they must be brought to stand before God, to be judged of their works; and if their works have been filthiness they must needs be filthy; and if they be filthy it must needs be that they cannot dwell in the kingdom of God; if so, the kingdom of God must be filthy also.

But behold, I say unto you, the kingdom of God is not filthy, and there cannot any unclean thing enter into the kingdom of God; wherefore there must needs be a place of filthiness prepared for that which is filthy.

35 Мөн тийм байр бэлтгэгдсэн, тийм ээ, бүр миний ярьсан тэр, мөн чөтгөр бэлтгэгч нь болох тэр аймшигт там; иймийн тул хүмүүний сүнсний сүүлийн байдал Бурханы хаант улсад оршино, эсвээс миний ярьсан шударга ёсны учир зайлуулагдана.

36 Иймийн тул, ёс бусыг үйлдэгсэд нь зөв шударгыг үйлдэгсэд болон амьдралын модноос тусгаарлагдах болно, жимс нь бусад бүх жимснээс илүү хамгийн үнэт мөн хамгийн хүсэл татам болох тэр болой; тийм ээ, мөн энэ нь Бурханы бүх бэлэгнүүдээс хамгийн агуу нь билээ. Мөн би ах нартаа ийн ярьсан бөлгөө. Амен.

And there is a place prepared, yea, even that awful hell of which I have spoken, and the devil is the preparator of it; wherefore the final state of the souls of men is to dwell in the kingdom of God, or to be cast out because of that justice of which I have spoken.

Wherefore, the wicked are rejected from the righteous, and also from that tree of life, whose fruit is most precious and most desirable above all other fruits; yea, and it is the greatest of all the gifts of God. And thus I spake unto my brethren. Amen.

## 1 Нифай 16

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор би, Нифай, ах нар-таа хандсан яриагаа төгсгөл болгосны дараа, бол-гоогтун, тэд надад хандан: Бидний тэвчих чадлаас хэтэрсэн хатуу зүйлийг чи бидэнд айлдав хэмээв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэдэнд хандан би үнэ-ний дагуу ёсон бусыг үйлдэгсдийн эсрэг хатуу зүй-лийг ярьсан гэдгээ би мэдсэн гэж хэлэв; мөн би зөв шударгыг үйлдэгсдийг зөвтгөн, мөн тэд хожмын өдөр өргөмжлөгдсөн байхыг гэрчлэв; иймийн тул гэмтнүүдэд, энэ нь тэдний зүрхийг зүсэх учир үнэн хатуу санагдах бөлгөө.
- 3 Мөн эдүгээ ах нар минь, хэрэв та нар зөв шударга мөн үнэнийг дуртайяа анхааран сонсдог, мөн Бурханы өмнө үнэн шударгаар явж болохын тул үүнд анхаарлаа хандуулдагсан бол, та нар үнэний учир бувтналдаж: Чи бидний эсрэг хэцүү зүйлийг ярив хэмээхгүй байсан.
- 4 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Их Эзэний зарлигуудыг дага хэмээн байдгаараа хичээн-гүйлэн ах нартаа ухуулав.
- 5 Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусгав; үүний хэрээр тэднийг зөв шу-даргын замаар алхлах болов уу хэмээх их найдлага мөн баясал надад төрөв.
- 6 Эдүгээ, эдгээр бүх зүйл Лемүелийн гэж түүний нэрлэсэн тэр хөндийд эцэг минь майханд оршин сууж ахуйд хэлэгдсэн мөн хийгдсэн бөлгөө.
- 7 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Ишмэилийн охидын нэгийг эхнэр болгон авав; мөн түүнчлэн, миний ах нар Ишмэилийн охидыг эхнэр болгон авцгаав; мөн түүнчлэн Зорам Ишмэилийн ууган охиныг эхнэр болгон авав.
- 8 Мөн тийн миний эцэг түүнд өгөгдсөн Их Эзэний бүх зарлигийг гүйцэлдүүлсэн байв. Мөн түүнчлэн би, Нифай Их Эзэнээр адислагдсан нь үлэмж бөл-гөө.
- 9 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой эцэгт минь хандан шөнөөр ярьж, мөн тэр ирэх өдөр аглаг буйдад өөрийн аянаа хөөвөл зохино хэмээн түүнд зарлигласан бөлгөө.

## 1 Nephi 16

And now it came to pass that after I, Nephi, had made an end of speaking to my brethren, behold they said unto me: Thou hast declared unto us hard things, more than we are able to bear.

And it came to pass that I said unto them that I knew that I had spoken hard things against the wicked, according to the truth; and the righteous have I justified, and testified that they should be lifted up at the last day; wherefore, the guilty taketh the truth to be hard, for it cutteth them to the very center.

And now my brethren, if ye were righteous and were willing to hearken to the truth, and give heed unto it, that ye might walk uprightly before God, then ye would not murmur because of the truth, and say: Thou speak-est hard things against us.

And it came to pass that I, Nephi, did exhort my brethren, with all diligence, to keep the commandments of the Lord.

And it came to pass that they did humble themselves before the Lord; insomuch that I had joy and great hopes of them, that they would walk in the paths of righteousness.

Now, all these things were said and done as my father dwelt in a tent in the valley which he called Lemuel.

And it came to pass that I, Nephi, took one of the daughters of Ishmael to wife; and also, my brethren took of the daughters of Ishmael to wife; and also Zoram took the eldest daughter of Ishmael to wife.

And thus my father had fulfilled all the commandments of the Lord which had been given unto him. And also, I, Nephi, had been blessed of the Lord exceedingly.

And it came to pass that the voice of the Lord spake unto my father by night, and commanded him that on the morrow he should take his journey into the wilder-ness.



10 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь өглөө дээшлэн мөн майхны үүдэнд ирэхдээ гайхал бахдалыг нь төрүүлэн газарт буй уран чамин хийцтэй бөмбөрцгийг олж харав; мөн энэ нь сайн чанарын гууль байв. Мөн тэр бөмбөрцөг хоёр зүүтэй байв; нэг зүү нь аглаг буйдад бидний хааш явбал зохих замыг заах болой.

11 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйд тийш авч явбал зохих зүйлүүдээ, мөн Их Эзэн бидэнд өгсөн хоол хүнсний бүх үлдэгдлийг нэгтгэн цуглуулав; мөн бид зүйл бүрийн үрийг аглаг буйдад тээхээр авав.

12 Мөнхүү улиран тохиох дор бид майхнуудаа авч, Лемений голыг гатлан аглаг буйд тийш одов.

13 Мөнхүү улиран тохиох дор бид дөрвөн өдрийн турш зүүн урд, урд зүгийг баримжаалан аялаад, мөн бид майхнуудаа дахин босгов; мөн бид уг нутгийг Шазер хэмээх нэрээр нэрлэв.

14 Мөнхүү улиран тохиох дор бид нум сумаа агсан, мөн гэр бүлийнхэндээ хүнс бэлтгэхээр аглаг буйдад одов; мөн бид гэр бүлийнхэндээ зориулж ан агнаад дараа нь аглаг буйд дахь Шазер нутагт гэр бүлийнхэндээ эргэж ирэв. Тэгээд бид урьдын адил чигийг барин, аглаг буйдын Улаан Тэнгисийн эрэг дагуу орших хамгийн шимт сайхан хэстийг даган аглаг буйдад дахин одов.

15 Мөнхүү улиран тохиох дор бид нум сумаараа болон чулуу хийгээд дүүгүүрээрээ замдаа ан хийж, олон өдрийн турш аялав.

16 Мөн бид аглаг буйдын арай илүү үржил шимтэй сайхан хэсгээр нь дагуулах тэр бөмбөрцгийн заах чиглэлийг дагаж явсан бөлгөө.

17 Мөн бид олон хоногийн турш аялсныхаа дараа бид хэсэг хугацаанд өөрсдийгөө дахин амрааж мөн гэр бүлийнхэндээ хүнс залгуулахаар майхнуудаа босгон буудаллав.

18 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай ан агнахаар явахдаа, болгоогтун, сайн гангаар хийсэн нумаа хугалчихав; тэгээд би нумаа хугалсны дараа, болгоогтун, ах нар маань намайг нумаа алдаж, бид хүнс залгуулаагүйн учир надад уурлав.

And it came to pass that as my father arose in the morning, and went forth to the tent door, to his great astonishment he beheld upon the ground a round ball of curious workmanship; and it was of fine brass. And within the ball were two spindles; and the one pointed the way whither we should go into the wilderness.

And it came to pass that we did gather together whatsoever things we should carry into the wilderness, and all the remainder of our provisions which the Lord had given unto us; and we did take seed of every kind that we might carry into the wilderness.

And it came to pass that we did take our tents and depart into the wilderness, across the river Laman.

And it came to pass that we traveled for the space of four days, nearly a south-southeast direction, and we did pitch our tents again; and we did call the name of the place Shazer.

And it came to pass that we did take our bows and our arrows, and go forth into the wilderness to slay food for our families; and after we had slain food for our families we did return again to our families in the wilderness, to the place of Shazer. And we did go forth again in the wilderness, following the same direction, keeping in the most fertile parts of the wilderness, which were in the borders near the Red Sea.

And it came to pass that we did travel for the space of many days, slaying food by the way, with our bows and our arrows and our stones and our slings.

And we did follow the directions of the ball, which led us in the more fertile parts of the wilderness.

And after we had traveled for the space of many days, we did pitch our tents for the space of a time, that we might again rest ourselves and obtain food for our families.

And it came to pass that as I, Nephi, went forth to slay food, behold, I did break my bow, which was made of fine steel; and after I did break my bow, behold, my brethren were angry with me because of the loss of my bow, for we did obtain no food.

- 19 Мөнхүү улиран тохиох дор бид гэрийнхэндээ хүнсгүй буцаж ирэв, тэд аяныхаа улмаас ихэд эцэж ядарсан учир хоол хүнсээр гачигдаж ихэд шаналан байв.
- 20 Мөнхүү улиран тохиох дор Лемел болон Лемүел мөн Ишмэилийн хөвгүүд аглаг буйд дахь зовлон болон зүдгүүрүүдийнхээ улмаас үлэмж ихээр бувтналдаж эхлэв; мөн түүнчлэн эцэг минь Их Эзэн Бурханыхаа эсрэг бувтнаж эхлэв; тийм ээ, мөн тэд бүгд бүр Их Эзэний эсрэг бувтналдахаар тийм их үлэмжийн уй гашууд автагдсан байв.
- 21 Эдүгээ улиран тохиох дор би, Нифай, нумаа алдсан мөн тэдний нум хөвчгүй байсан учир ах нартайгаа хамт зовон байв, үлэмж хэцүү болж эхлэв, тийм ээ, үүний хэрээр бид хүнс залгуулж чадахгүй болоо.
- 22 Мөнхүү улиран тохиох дор тэд зүрх сэтгэлээ дахин хатууруулж, бүр Их Эзэн Бурханыхаа эсрэг гомдоллож байсан учир би, Нифай, ах нартаа хандан ихийг ярив.
- 23 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, модоор нум, шулуун саваагаар сум хийв; иймийн тул, би өөрийгөө нум сум, дүүгүүр бас чулуугаар зэвсэглэв. Мөн би эцэгтээ хандан: Хааш одож би хүнс залгуулах билээ хэмээв.
- 24 Мөнхүү улиран тохиох дор тэд миний үгсийн учир өөрсдийгөө төлөв даруу болгосон тул тэрээр Их Эзэнээс гуйв; өөрөөр хэлбэл би бодгалийнхаа эрч хүчээр тэдэнд хандан олон зүйлийг ярьсны учир болой.
- 25 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой эцэгт минь ирэв; мөн тэрээр Их Эзэний эсрэг бувтнасан учир тэр үнэхээр зэмлэгдсэн бөлгөө үүний хэрээр тэр гүнээ харамсалд орсон байв.
- 26 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой түүнд хандан: Бөмбөрцгийн дээрхийг хар, мөн бичигдсэн зүйлийг болгоогтун хэмээв.
- 27 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь бөмбөрцөг дээр бичигдсэн тэр зүйлийг хараад, тэрээр, мөн түүнчлэн миний ах нар болон Ишмэилийн хөвгүүд мөн бидний эхнэрүүд үлэмж ихээр айж, чичирцгээж байв.

And it came to pass that we did return without food to our families, and being much fatigued, because of their journeying, they did suffer much for the want of food.

And it came to pass that Laman and Lemuel and the sons of Ishmael did begin to murmur exceedingly, because of their sufferings and afflictions in the wilderness; and also my father began to murmur against the Lord his God; yea, and they were all exceedingly sorrowful, even that they did murmur against the Lord.

Now it came to pass that I, Nephi, having been afflicted with my brethren because of the loss of my bow, and their bows having lost their springs, it began to be exceedingly difficult, yea, insomuch that we could obtain no food.

And it came to pass that I, Nephi, did speak much unto my brethren, because they had hardened their hearts again, even unto complaining against the Lord their God.

And it came to pass that I, Nephi, did make out of wood a bow, and out of a straight stick, an arrow; wherefore, I did arm myself with a bow and an arrow, with a sling and with stones. And I said unto my father: Whither shall I go to obtain food?

And it came to pass that he did inquire of the Lord, for they had humbled themselves because of my words; for I did say many things unto them in the energy of my soul.

And it came to pass that the voice of the Lord came unto my father; and he was truly chastened because of his murmuring against the Lord, insomuch that he was brought down into the depths of sorrow.

And it came to pass that the voice of the Lord said unto him: Look upon the ball, and behold the things which are written.

And it came to pass that when my father beheld the things which were written upon the ball, he did fear and tremble exceedingly, and also my brethren and the sons of Ishmael and our wives.

28 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, уг бөмбөрцөгт буй зүүнүүдийг болгоов, тэдгээр нь бидний тэдгээрт хандуулсан итгэл болон хичээнгүй байдал хийгээд анхаарлын дагуу ажилладаг байв.

29 Мөн тэдгээрийн дээр түүнчлэн уншихад илэрхий, Их Эзэний замын талаар бидэнд ойлголт өгөх шинэ бичиглэл байв; мөн энэ нь түүнд хандах бидний итгэл хичээл зүтгэлийн дагуу цагаас цагт өөрчлөгдөн бичигдэж байсан ажгуу. Мөн бид тийн өчүүхэн арга замаар Их Эзэн агуу үйл хэргүүдийг тохиох болгож чадахыг харав.

30 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, бөмбөрцөг дээр өгөгдсөн тэр чиглэлийн дагуу уулын оргилыг зүглэн явлаа.

31 Мөнхүү улиран тохиох дор би зэрлэг амьтан агнаж, чингээд би гэр бүлийнхэндээ хүнс залгуулав.

32 Мөнхүү улиран тохиох дор би алсан амьтнаа үүрсээр майхнууддаа эргэж ирэв; мөн эдүгээ тэд намайг хүнс олж ирснийг хараад, тэдний баяр хөөр хичнээн их байсан гээч! Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, мөн түүнд талархал мэдүүлэв.

33 Мөнхүү улиран тохиох дор бид дахин аяны харгуйг хөөн, эхний удаад аялсантай ойролцоо чиглэлд явав; мөн бид олон хоногийн турш аялаад бид хэсэг хугацаанд буудаллахаар майхнуудаа дахин босгов.

34 Мөнхүү улиран тохиох дор Ишмэил нас барж, мөн Нахом хэмээх нутагт оршуулагдав.

35 Мөнхүү улиран тохиох дор Ишмэилийн охид эцгээ алдсан учир, басхүү аглаг буйд дахь зовлон зүдгүүрүүдийн учир үлэмж гашуудан байв; мөн тэд эцгийн минь эсрэг, тэр тэднийг Иерусалим газраас авчирсны учир бувтналдан, өгүүлсэн нь: Бидний эцэг үхэв; тийм ээ, бид аглаг буйдад ихээр бэдрэв, мөн бид зовж зүдэрч, өлсөж цанган бас ядарч ихэд зовов; мөн эдгээр бүх зовлонгуудын эцэст бид энэ аглаг буйдад өлсгөлөнгийн улмаас эрсдэх буйза хэмээв.

36 Мөн тэд тийн эцгийн минь эсрэг, мөн түүнчлэн миний эсрэг бувтналдав; мөн тэд Иерусалимын зүг дахин буцах хүсэлтэй байлаа.

And it came to pass that I, Nephi, beheld the pointers which were in the ball, that they did work according to the faith and diligence and heed which we did give unto them.

And there was also written upon them a new writing, which was plain to be read, which did give us understanding concerning the ways of the Lord; and it was written and changed from time to time, according to the faith and diligence which we gave unto it. And thus we see that by small means the Lord can bring about great things.

And it came to pass that I, Nephi, did go forth up into the top of the mountain, according to the directions which were given upon the ball.

And it came to pass that I did slay wild beasts, inso-much that I did obtain food for our families.

And it came to pass that I did return to our tents, bearing the beasts which I had slain; and now when they beheld that I had obtained food, how great was their joy! And it came to pass that they did humble themselves before the Lord, and did give thanks unto him.

And it came to pass that we did again take our journey, traveling nearly the same course as in the beginning; and after we had traveled for the space of many days we did pitch our tents again, that we might tarry for the space of a time.

And it came to pass that Ishmael died, and was buried in the place which was called Nahom.

And it came to pass that the daughters of Ishmael did mourn exceedingly, because of the loss of their father, and because of their afflictions in the wilderness; and they did murmur against my father, because he had brought them out of the land of Jerusalem, saying: Our father is dead; yea, and we have wandered much in the wilderness, and we have suffered much affliction, hunger, thirst, and fatigue; and after all these sufferings we must perish in the wilderness with hunger.

And thus they did murmur against my father, and also against me; and they were desirous to return again to Jerusalem.

37 Мөн Лемен, Лемүелд мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүдэд хандан: Болгоогтун, ах нар биднийхээ захирагч хийгээд багш болох үүргийг өөртөө авсан манай дүү Нифайг мөн түүнчлэн манай эцгийг бүгдээрээ алцгаая хэмээв.

38 Эдүгээ, Их Эзэн түүнтэй ярьсан, мөн түүнчлэн тэнгэр элчүүд түүнд тохинуулна гэж тэрээр хэлдэг. Гэвч болгоогтун, тэр бидэнд худал хэлж буйг бид мэднэ; мөн тэрээр бидний нүдийг хуурч болохын тулд, эдгээр зүйлийг тэр бидэнд хэлж мөн олон зүйлийг башир аргаар үйлдэн, магадгүй, биднийг харь этгээд аглаг буйд тийш дагуулан одож болно хэмээн бодож байгаа биз ээ; мөн тэр биднийг дагуулсны дараа тэр биднээр өөрийн дураар болон хүссэнийхээ дагуу хийлгэж болохын тулд тэр өөрийгөө бидний хаан мөн захирагч болгохыг бодсон ажээ. Мөн иймэрхүү маягаар миний ах Лемен тэдний зүрх сэтгэлийг өдөөн хатгаж уурлуулав.

39 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн бидэнтэй хамт байв, тийм ээ, бүр Их Эзэний дуу хоолой ирж мөн тэдэнд хандан олон үгийг ярив, мөн тэднийг үлэмж зэмлэсэн бөлгөө; мөн тэд Их Эзэний дуу хоолойгоор зэмлэгдсэний дараа тэд уурлахаа больж, мөн нүглүүдээ наманчлав, үүний хэрээр Их Эзэн биднийг дахин хоол хүнсээр адисалсан тул бид эрсдээгүй бөлгөө.

And Laman said unto Lemuel and also unto the sons of Ishmael: Behold, let us slay our father, and also our brother Nephi, who has taken it upon him to be our ruler and our teacher, who are his elder brethren.

Now, he says that the Lord has talked with him, and also that angels have ministered unto him. But behold, we know that he lies unto us; and he tells us these things, and he worketh many things by his cunning arts, that he may deceive our eyes, thinking, perhaps, that he may lead us away into some strange wilderness; and after he has led us away, he has thought to make himself a king and a ruler over us, that he may do with us according to his will and pleasure. And after this manner did my brother Laman stir up their hearts to anger.

And it came to pass that the Lord was with us, yea, even the voice of the Lord came and did speak many words unto them, and did chasten them exceedingly; and after they were chastened by the voice of the Lord they did turn away their anger, and did repent of their sins, insomuch that the Lord did bless us again with food, that we did not perish.

## 1 Нифай 17

- 1 Мөнхүү улиран тохиох дор бид аглаг буйдад дахин аяндаа гарав; мөн бид тэр цагаас хойш барагцаалбал дорнодыг чиглэн аялсан бөлгөө. Мөн бид аялж бас аглаг буйдад зовлонгийн ихийг туулав; мөн манай бүсгүйчүүд аглаг буйдад хүүхдүүд төрүүлэв.
- 2 Мөн аглаг буйдад бид түүхий махаар амь зогоож байхад манай эмэгтэйчүүд хүүхдүүдээ хөхөөр элбэг цаггаж, бас тэд хүч тамиртай байв, тийм ээ бүр эр хүний адил байв; мөн тэд аяны замыг дургүйцэлгүйгээр эхэлж тэсэхүйц бидэн дээрх Их Эзэний адислалууд тийм агуу байв.
- 3 Мөн тийнхүү бид Бурханы зарлигууд биелэгдэх ёстойг харна. Мөн хүмүүний үрс Бурханы зарлигуудыг дагавал тэрээр тэднийг асран мөн тэднийг хүчирхэгжүүлж, бас тэдэнд өөрийн зарлигласан зүйлийг гүйцэлдүүлж чадах арга замуудыг хангаж өгөх бөлгөө; иймийн тул, тэрээр биднийг аглаг буйдад нүүдэллэж байх зуур аливаа арга замуудаар хангаж байв.
- 4 Мөн бид олон жилийн турш нүүдлийн байдалд байв, тийм ээ, бүр найман жил аглаг буйдад байлаа.
- 5 Мөн жимс мөн түүнчлэн зэрлэг зөгийн бал элбэгтэй учир Өгөөмөр хэмээн бидний нэрлэсэн нутагт бид хүрч ирэв; мөн эдгээр бүх зүйл биднийг эрсдүүлэхгүйн тулд Их Эзэнээр бэлтгэгдсэн байлаа. Мөн Иррентум хэмээн бидний нэрлэсэн, орчуулбал их усан гэгдэх тэнгисийг бид харав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор бид тэнгисийн эрэгт майхнуудаа босгов; мөн бид их зовлон, олон бэрхийг туулж, тийм ээ, бүр бид бүгдийг нь бичиж чадахааргүй ихийг буюу, гэсэн хэдий ч, бид тэнгисийн эрэгт ирэх үедээ үлэмж баяртай байв; мөн бид их жимстэйн учир уг нутгийг Өгөөмөр хэмээн нэрлэв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, Өгөөмөр нутагт олон өдөр өнжсөний дараа Их Эзэний дуу хоолой надад ирж, өгүүлсэн нь: Бос, мөн ууланд гар хэмээв. Мөнхүү улиран тохиох дор би босч мөн ууланд дээр гараад, Их Эзэнд хандан залбирав.

## 1 Nephi 17

And it came to pass that we did again take our journey in the wilderness; and we did travel nearly eastward from that time forth. And we did travel and wade through much affliction in the wilderness; and our women did bear children in the wilderness.

And so great were the blessings of the Lord upon us, that while we did live upon raw meat in the wilderness, our women did give plenty of suck for their children, and were strong, yea, even like unto the men; and they began to bear their journeyings without murmurings.

And thus we see that the commandments of God must be fulfilled. And if it so be that the children of men keep the commandments of God he doth nourish them, and strengthen them, and provide means whereby they can accomplish the thing which he has commanded them; wherefore, he did provide means for us while we did sojourn in the wilderness.

And we did sojourn for the space of many years, yea, even eight years in the wilderness.

And we did come to the land which we called Bountiful, because of its much fruit and also wild honey; and all these things were prepared of the Lord that we might not perish. And we beheld the sea, which we called Irreantum, which, being interpreted, is many waters.

And it came to pass that we did pitch our tents by the seashore; and notwithstanding we had suffered many afflictions and much difficulty, yea, even so much that we cannot write them all, we were exceedingly rejoiced when we came to the seashore; and we called the place Bountiful, because of its much fruit.

And it came to pass that after I, Nephi, had been in the land of Bountiful for the space of many days, the voice of the Lord came unto me, saying: Arise, and get thee into the mountain. And it came to pass that I arose and went up into the mountain, and cried unto the Lord.

8 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад ярьж, өгүүлсэн нь: Би чиний хүмүүсийг энэ усыг гаталгахын тулд, чамд миний үзүүлэх тэр жаягаар, чи усан онгоц барих болно хэмээв.

9 Мөн би хэлэв: Их Эзэн, би хааш одож надад таны үзүүлсэн тэр жаягийн дагуу онгоц барих багаж хийж болох хайлуулах хүдрийг олох билээ би

10 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн багаж хийж болох хүдэр олохын тулд хааш явах ёстойг надад хэлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай амьтны ширээр, гал үлээлгэх хөөрөг хийв; мөн гал хөөргөдөх хэрэгсэлтэй байж болохын тулд би хөөрөг хийсний дараа, гал үүсгэж болохын тулд хоёр чулуу харшуулан цахив.

12 Учир нь, Их Эзэн эдүгээ болтол биднийг аглаг буйдад аялах зуураа гал өрдөхийг зөвшөөрөөгүй билээ; учир нь тэрээр хэлэв: би та нарын хүнсийг гал дээр болгох шаардлагагүйгээр амт оруула.

13 Мөн түүнчлэн аглаг буйдад би та нарын гэрэл байх болно; мөн би та нарын өмнө замыг бэлтгэнэ, хэрэв та нар миний зарлигуудыг дагавал; иймийн тул, та нар миний зарлигийг дагахын хэрээр, та нар амлагдсан нутгийн зүг удирдагдах болно; мөн та нар надаар удирдагдаж байгаага мэдэх болно.

14 Тиймээ, мөн Их Эзэн түүнчлэн хэлэв: Та нар амлагдсан нутагт хүрсний дараа, Их Эзэн, би бол Бурхан мөн гэдгийг та нар мэдэх болно; мөн Их Эзэн би, та нарыг устгалаас зайлуулсан; тийм ээ, би та нарыг Иерусалим нутгаас гаргаж авчирсныг буюу.

15 Иймийн тул, би, Нифай, Их Эзэний зарлигуудыг дагахаар мэрийсэн, мөн итгэлтэй бас хичээнгүй байхыг би ах нартаа ухуулсан билээ.

16 Мөнхүү улиран тохиох дор би хаднаас хайлуулсан хүдрээр багаж хийв.

17 Мөн ах нар маань намайг усан онгоц барих гэж буйг хараад, тэд миний эсрэг бувтналдаж эхлэв, өгүүлсэн нь: Дүү маань мулгуу юм, учир нь тэр өөрийгөө усан онгоц барьж чадна хэмээн сэтгэнэ; тийм ээ, мөн түүнчлэн тэр энэ агуу их усыг гаталж чадна гэж бодох ажээ.

And it came to pass that the Lord spake unto me, saying: Thou shalt construct a ship, after the manner which I shall show thee, that I may carry thy people across these waters.

And I said: Lord, whither shall I go that I may find ore to molten, that I may make tools to construct the ship after the manner which thou hast shown unto me?

And it came to pass that the Lord told me whither I should go to find ore, that I might make tools.

And it came to pass that I, Nephi, did make a bellows wherewith to blow the fire, of the skins of beasts; and after I had made a bellows, that I might have wherewith to blow the fire, I did smite two stones together that I might make fire.

For the Lord had not hitherto suffered that we should make much fire, as we journeyed in the wilderness; for he said: I will make thy food become sweet, that ye cook it not;

And I will also be your light in the wilderness; and I will prepare the way before you, if it so be that ye shall keep my commandments; wherefore, inasmuch as ye shall keep my commandments ye shall be led towards the promised land; and ye shall know that it is by me that ye are led.

Yea, and the Lord said also that: After ye have arrived in the promised land, ye shall know that I, the Lord, am God; and that I, the Lord, did deliver you from destruction; yea, that I did bring you out of the land of Jerusalem.

Wherefore, I, Nephi, did strive to keep the commandments of the Lord, and I did exhort my brethren to faithfulness and diligence.

And it came to pass that I did make tools of the ore which I did molten out of the rock.

And when my brethren saw that I was about to build a ship, they began to murmur against me, saying: Our brother is a fool, for he thinketh that he can build a ship; yea, and he also thinketh that he can cross these great waters.

18 Мөн ийн ах нар минь миний эсрэг гомдоллож, мөн тэд намайг усан онгоц барьж чадна гэж итгээгүйн учир, тэд хөдөлмөрлөхгүй байх хүсэлтэй байсан буюу; бас тэд намайг Их Эзэнээр зааварлагдаж байсан гэдэгт ч итгэсэнгүй.

19 Мөн эдүгээ улиран тохиох дор би, Нифай, тэдний зүрх сэтгэл хатуугийн учир үлэмж ихээр харамсан байв; мөн эдүгээ тэд намайг харамсаж эхлэхийг хараад дотроо баярлаж, үүнийхээ хэрээр тэд намайг давсандаа эрэмшиж, өгүүлсэн нь: Бид чамайг усан онгоц барьж чадахгүйг чинь мэдсэн, учир нь чадал чинь хүрэхгүйг бид мэдсэн; иймийн тул, чи ийм агуу үйлийг гүйцэлдүүлж чадахгүй.

20 Мөн чи зүрх сэтгэлийнхээ мунхаг төсөөлөлд хөтлөгдөх бидний эцэгтэй адил юм; тийм ээ, тэр биднийг Иерусалим нутгаас удирдан гаргасан, мөн бид аглаг буйдад өдий олон жил бэдрэн явна; мөн бидний эмэгтэйчүүд бие давхар байж хүнд ажилд зүтгэв; мөн тэд аглаг буйдад хүүхдүүдээ төрүүлж мөн бүх зүйлийн зовлонг, үхэхээс бусдыг л үзлээ; мөн тэд Иерусалимаас гарч ирэхээсээ өмнө үхсэн бол эдгээр зовлонгуудыг туулснаас хавьгүй дээр байх байсан биз ээ.

21 Болгоогтун, энэ олон жил бид аглаг буйдад зовов, бид өөрсдийн эд хөрөнгө болон өвлөсөн нутагтаа сайхан байж болох байсан; тийм ээ, мөн бид баяр хөөртэй байж болох байсан.

22 Мөн Иерусалим газарт байсан тэдгээр хүмүүс зөв шударга хүмүүс байсныг бид мэднэ; учир нь тэд Их Эзэний дүрмүүд болон шийдвэрүүдийг мөн түүний бүх зарлигуудыг Мосегийн хуулийн дагуу сахьдаг байсан бөлгөө; иймийн тул, тэд бол зөв шударга хүмүүс гэдгийг бид мэднэ; мөн бидний эцэг тэднийг шүүж, мөн бид түүний үгсийг анхааран сонсох учраас биднийг алсад удирдсан юм; тийм ээ, мөн бидний дүү түүнтэй адил юм. Мөн иймэрхүү маягийн хэлээр ах нар маань бидний эсрэг гомдоллон бувталдав.

23 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэдэнд хандан ярьж, хэлрүүн: Израилын үр удам болох, бидний эцэг өвгөд хэрэв Их Эзэний үгсийг анхаараагүй сэн бол египетчүүдийн гараас гарах байсан гэдэгт та нар итгэдэг үү

And thus my brethren did complain against me, and were desirous that they might not labor, for they did not believe that I could build a ship; neither would they believe that I was instructed of the Lord.

And now it came to pass that I, Nephi, was exceedingly sorrowful because of the hardness of their hearts; and now when they saw that I began to be sorrowful they were glad in their hearts, insomuch that they did rejoice over me, saying: We knew that ye could not construct a ship, for we knew that ye were lacking in judgment; wherefore, thou canst not accomplish so great a work.

And thou art like unto our father, led away by the foolish imaginations of his heart; yea, he hath led us out of the land of Jerusalem, and we have wandered in the wilderness for these many years; and our women have toiled, being big with child; and they have borne children in the wilderness and suffered all things, save it were death; and it would have been better that they had died before they came out of Jerusalem than to have suffered these afflictions.

Behold, these many years we have suffered in the wilderness, which time we might have enjoyed our possessions and the land of our inheritance; yea, and we might have been happy.

And we know that the people who were in the land of Jerusalem were a righteous people; for they kept the statutes and judgments of the Lord, and all his commandments, according to the law of Moses; wherefore, we know that they are a righteous people; and our father hath judged them, and hath led us away because we would hearken unto his words; yea, and our brother is like unto him. And after this manner of language did my brethren murmur and complain against us.

And it came to pass that I, Nephi, spake unto them, saying: Do ye believe that our fathers, who were the children of Israel, would have been led away out of the hands of the Egyptians if they had not hearkened unto the words of the Lord?

- 24 Тийм ээ, хэрэв тэднийг боолчлолоос удирдан гаргахыг Их Эзэн Мосед зарлиг болгоогүйсэн бол, тэд боолчлолоос удирдагдан гарах байсан гэж бодно уу, та нар
- 25 Эдүгээ Израилын хүүхдүүд боолчлолд байсныг та нар мэднэ; мөн тэд тэсэхэд хэцүү тэр үүргийг тээж явсныг та нар мэднэ; иймийн тул, тэд боолчлолоос гаргагдан авчрагдсан нь тэдэнд сайн зүйл болсон нь гарцаагүйг та нар мэднэ.
- 26 Мосе тэр агуу үйлийг хийхээр Их Эзэнээс зарлиглагдсан байсныг эдүгээ та нар мэднэ; мөн та нар түүний үгээр Улаан Тэнгисийн ус нааш цааш ярагдан, мөн тэд хуурай газар дээгүүр хөндлөн гарч ирснийг мэднэ.
- 27 Харин Фараоны их цэрэг болох тэр египетчүүд Улаан Тэнгист живснийг та нар мэднэ.
- 28 Мөн түүнчлэн тэд аглаг буйдад манна гэгчээр тэжээгдэж байсныг та нар мэднэ.
- 29 Тийм ээ, мөн түүнчлэн Мосе өөрийн үгээр, түүнд байсан Бурханы хүчний дагуу хадыг түншиж, тэндээс ус гарахад Израилын хүүхдүүд цангаага тайлж чадах болсныг та нар мэдэх бөлгөө.
- 30 Мөн тэдний өмнө явж, өдөр нь тэднийг дагуулан мөн шөнө нь гэрэл гэгээ өгч, мөн хүнд хэрэглэгдвэл зохих тэдгээр бүх зүйлийг тэдэнд хийж өгсөн Их Эзэн Бурханаараа, өөрсдийн Гэтэлгэгчээр тэд удирдагдан байсан атал, тэд зүрх сэтгэлээ хатууруулан мөн оюунаа харалган болгож, Мосегийн эсрэг мөн үнэн болоод амьд Бурханы эсрэг хорон мууг өгүүлж байсан билээ.
- 31 Мөнхүү улиран тохиох дор өөрийн үгсийн дагуу тэр тэднийг устгасан бөлгөө; мөн өөрийн үгсийн дагуу тэр тэднийг удирдаж; мөн өөрийн үгсийн дагуу тэр тэдэнд бүх зүйлийг хийж өгсөн билээ; мөн түүний үгээр бус нэгээхэн ч зүйл эс тохиов.
- 32 Мөн тэд Иордан голыг гаталсны дараа тэрээр тэднийг уг нутгийн хүүхдүүдийг хөөн зайлуулахаар, тийм ээ, тэднийг устгалд нь хүргэн тараах хүчтэй болгосон буюу.

Yea, do ye suppose that they would have been led out of bondage, if the Lord had not commanded Moses that he should lead them out of bondage?

Now ye know that the children of Israel were in bondage; and ye know that they were laden with tasks, which were grievous to be borne; wherefore, ye know that it must needs be a good thing for them, that they should be brought out of bondage.

Now ye know that Moses was commanded of the Lord to do that great work; and ye know that by his word the waters of the Red Sea were divided hither and thither, and they passed through on dry ground.

But ye know that the Egyptians were drowned in the Red Sea, who were the armies of Pharaoh.

And ye also know that they were fed with manna in the wilderness.

Yea, and ye also know that Moses, by his word according to the power of God which was in him, smote the rock, and there came forth water, that the children of Israel might quench their thirst.

And notwithstanding they being led, the Lord their God, their Redeemer, going before them, leading them by day and giving light unto them by night, and doing all things for them which were expedient for man to receive, they hardened their hearts and blinded their minds, and reviled against Moses and against the true and living God.

And it came to pass that according to his word he did destroy them; and according to his word he did lead them; and according to his word he did do all things for them; and there was not any thing done save it were by his word.

And after they had crossed the river Jordan he did make them mighty unto the driving out of the children of the land, yea, unto the scattering them to destruction.



33 Мөн эдүгээ, та нар ийн бодно уу, амлалтын нутагт байсан, бидний эцэг өвгөдөөр хөөгдөн гаргагдсан, энэ нутгийн хүүхдүүдийг, тэднийг та нар зөв шударга байсан гэж бодно уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй.

34 Хэрэв тэд зөв шударга байсан бол бидний эцэг өвгөд тэднээс илүүтэйгээр сонгомол гэж та нар бодно уу? Би та нарт хэлнэ, Үгүй.

35 Болгоогтун, Их Эзэн бүх биесийг адилтган үзнэ; зөв шударга байгч тэрээр Бурханы ээл хишгийг хүртдэг. Гэвч болгоогтун, энэ хүмүүс Бурханы үг бүрийг эсэргүүцэж, мөн тэдний алдас боловсорч гүйцээд байв; мөн Бурханы хилэн тэр чигээрээ тэдний дээр байв; мөн Их Эзэн уг нутгийг тэдний эсрэг болгон зүхэж, мөн бидний эцэг өвгөдийн төлөө үүнийг адисалсан юм; тийм ээ, тэрээр үүнийг тэдний эсрэг, устгалд нь хүртэл зүхэж, мөн тэрээр бидний эцэг өвгөдийг, үүнийг эзэмших хүчээр тэднийг адисалсан юм.

36 Болгоогтун, Их Эзэн газар дэлхийг оршин суугчдынх нь төлөө бүтээсэн юм; мөн тэрнийг тэднээр эзэмшүүлэхийн тулд тэрээр өөрийн хүүхдүүдийг бүтээсэн юм.

37 Мөн тэрээр зөв шударга үндэстнийг өсгөн, мөн ёсон бусыг үйлдэгч үндэстнүүдийг устгах болно.

38 Мөн тэрээр зөв шударгыг үйлдэгчдийг эрхэм сайхан нутаг тийш удирдаж, мөн ёсон бусыг үйлдэгчдийг тэрээр устган, мөн тэдний улмаас, тэдэнд уг нутгийг зүхэх бөлгөө.

39 Тэрээр өндөр тэнгэрт ноёлдог, учир нь энэ бол түүний сэнтий, мөн энэ дэлхий бол түүний хөлийн гишгүүр юм.

40 Мөн тэрээр өөрийг нь Бурханаа болгогч тэднийг хайрладаг. Болгоогтун, тэрээр бидний эцэг өвгөдийг хайрлаж, тийм ээ, бүр Абрахам, Исаак мөн Иаковыг, мөн тэрээр тэдэнтэй гэрээ хийсэн билээ; мөн тэрээр өөрийн хийсэн гэрээнүүдийг санасан буюу; иймийн тул, тэрээр тэднийг Египет газраас гарган авчирсан бөлгөө.

And now, do ye suppose that the children of this land, who were in the land of promise, who were driven out by our fathers, do ye suppose that they were righteous? Behold, I say unto you, Nay.

Do ye suppose that our fathers would have been more choice than they if they had been righteous? I say unto you, Nay.

Behold, the Lord esteemeth all flesh in one; he that is righteous is favored of God. But behold, this people had rejected every word of God, and they were ripe in iniquity; and the fulness of the wrath of God was upon them; and the Lord did curse the land against them, and bless it unto our fathers; yea, he did curse it against them unto their destruction, and he did bless it unto our fathers unto their obtaining power over it.

Behold, the Lord hath created the earth that it should be inhabited; and he hath created his children that they should possess it.

And he raiseth up a righteous nation, and destroyeth the nations of the wicked.

And he leadeth away the righteous into precious lands, and the wicked he destroyeth, and curseth the land unto them for their sakes.

He ruleth high in the heavens, for it is his throne, and this earth is his footstool.

And he loveth those who will have him to be their God. Behold, he loved our fathers, and he covenanted with them, yea, even Abraham, Isaac, and Jacob; and he remembered the covenants which he had made; wherefore, he did bring them out of the land of Egypt.

41 Мөн тэрээр өөрийн саваагаар аглаг буйдад тэднийг шийтгэв; учир нь тэд яг та нарын адил зүрх сэтгэлээ хатууруулсан билээ; мөн Их Эзэн тэдний хорт явдлын улмаас тэднийг шийтгэв. Тэрээр харвагч хорт могойнуудыг тэдний дунд илгээсэн бөлгөө; мөн тэднийг хазуулсны дараа тэрээр эдгэрч болох замыг бэлтгэсэн ажгуу; мөн тэдний гүйцэлдүүлэх ёстой ажил нь харах байв; мөн уг замын энгийн байдал эсвэл үүний амархны учир тэдгээрээс эрсэдсэн нь олон байв.

42 Мөн тэд цагаас цагт зүрх сэтгэлээ хатууруулж, мөн Мосегийн эсрэг, мөн түүнчлэн Бурханы эсрэг тэд хорт мууг өгүүлж байв; гэсэн хэдий ч, түүний зүйрлэшгүй хүчээр амлалтын нутагт тэд удирдагдсаныг та нар мэднэ.

43 Мөн эдүгээ, эдгээр бүх зүйлийн дараа, тэдний ёсон бус байх цаг ирлээ, тийм ээ, бараг л бүрэн засарсан; мөн энэ өдөр тэд бараг устгагдах гэж байж ч магад, би эс мэднэ; учир нь боолчлолд хүргэгдэх тэдний цөөн хэдээс бусад нь устгагдах ёстой тэр өдөр гарцаагүй ирэх ёстойг би мэднэ.

44 Иймийн тул, тэрээр аглаг буйд тийш одвол зохино хэмээн Их Эзэн эцэгт минь зарлигласан ажгуу; мөн түүнчлэн иудейчүүд түүний амийг авахыг эрэлхийлэв; тийм ээ, мөн та нар ч түүнчлэн түүний амийг авахаар эрэлхийлсэн; иймийн тул, та нар зүрх сэтгэлдээ алуурчид, та нар бас тэдний адил бөлгөө.

45 Та нар алдсыг үйлдэхдээ шаламгай боловч Их Эзэн Бурханаа санахдаа удаан юм. Та нар тэнгэр элчийг харсан, мөн тэрээр та нарт ярьсан; тийм ээ, та нар түүний дуу хоолойг цагаас цагт сонссон; мөн тэрээр намуухан зөөлөн дуугаар та нарт ярьсан, гэвч та нар мэдрэхээс өнгөрсөн, иймээс та нар түүний үгсийг мэдэрч чадсангүй; иймийн тул, дэлхий салж хуваагдах мэт сэгсрэх аянгын дуугаар тэрээр та нарт ярьсан билээ.

46 Мөн түүнчлэн тэрбээр өөрийн бүхнийг чадагч үгийн хүчээр газар дэлхийг ч үгүй болгож чадахыг та нар мэднэ; тийм ээ, мөн тэр өөрийн үгээр бартаатай газрыг тэгш сайхан, мөн тэгш сайхан нутгуудыг эвдэж чадахыг та нар мэднэ. Өө, тэгвэл, яагаад зүрх сэтгэлдээ ийм хатуу байж чадна вэ, та нар

And he did straiten them in the wilderness with his rod; for they hardened their hearts, even as ye have; and the Lord straitened them because of their iniquity. He sent fiery flying serpents among them; and after they were bitten he prepared a way that they might be healed; and the labor which they had to perform was to look; and because of the simpleness of the way, or the easiness of it, there were many who perished.

And they did harden their hearts from time to time, and they did revile against Moses, and also against God; nevertheless, ye know that they were led forth by his matchless power into the land of promise.

And now, after all these things, the time has come that they have become wicked, yea, nearly unto ripeness; and I know not but they are at this day about to be destroyed; for I know that the day must surely come that they must be destroyed, save a few only, who shall be led away into captivity.

Wherefore, the Lord commanded my father that he should depart into the wilderness; and the Jews also sought to take away his life; yea, and ye also have sought to take away his life; wherefore, ye are murderers in your hearts and ye are like unto them.

Ye are swift to do iniquity but slow to remember the Lord your God. Ye have seen an angel, and he spake unto you; yea, ye have heard his voice from time to time; and he hath spoken unto you in a still small voice, but ye were past feeling, that ye could not feel his words; wherefore, he has spoken unto you like unto the voice of thunder, which did cause the earth to shake as if it were to divide asunder.

And ye also know that by the power of his almighty word he can cause the earth that it shall pass away; yea, and ye know that by his word he can cause the rough places to be made smooth, and smooth places shall be broken up. O, then, why is it, that ye can be so hard in your hearts?

47 Болгоогтун, бодгаль минь та нараас болоод зовлондоо урагдаж, мөн зүрх сэтгэл минь өвднөм; та нарыг үүрд зайлуулагдах болуузай хэмээн айнама би. Болгоогтун, би Бурханы Сүнсээр дүүрэн байнам, үүний хэрээр миний бие хүчгүй байна.

48 Мөн эдүгээ улиран тохиох дор намайг эдгээр үгсийг ярьсны дараа тэд надад уурлаж, мөн намайг тэнгисийн гүнд хаяхыг хүсч байв; мөн тэд надад гар хүрэхээр урагшлан ирэхэд би тэдэнд ярьж, өгүүлсэн нь: Бүхнийг Чадагч Бурханы нэрээр, надад бүү хүр хэмээн би та нарт зарлиглаж байна, учир нь бүр бүх биеийг минь төөнөх, Бурханы хүчээр би дүүргэгдээд байна; мөн хэн надад гар хүрнэв тэр нь бүр хатсан зэгстэй адил гандах болно; мөн тэрээр Бурханы хүчний өмнө юухан ч биш, учир нь Бурхан түүнийг цохих болно.

49 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, тэд эцгийнхээ эсрэг цаашид бувтналдах нь зохисгүй; бас Бурхан намайг усан онгоц баривал зохино хэмээн зарлигласан тул, тэд надаас өөрсдийн хөдөлмөрийг харамлах учиргүй хэмээн тэдэнд хэлэв.

50 Мөн би тэдэнд хэлэв: Хэрэв Бурхан надад бүх зүйлийг зарлигласан бол би тэдгээрийг хийж чадах бөлгөө. Хэрэв би энэ усанд газар бол гэж хэлбэл зохино хэмээн тэр надад зарлигласан бол энэ нь газар болох сон; мөн хэрэв би үүнийг хэлэх юм бол энэ нь гүйцэлдэх болно.

51 Мөн эдүгээ, хэрэв Их Эзэн ийм агуу их хүчтэй байж, мөн хүмүүний үрсийн дунд ийм олон гайхамшгийг гүйцэлдүүлсэн бол, усан онгоц барихыг яахан тэрээр надад зааварлаж болохгүй байх билээ

52 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, ах нартаа хандан олон зүйлийг хэлж үүний хэрээр тэд шившиглэгдэж мөн миний эсрэг маргаж чадсангүй; бүр олон хоногийн турш надад гар хүрэх нь бүү хэл хуруугаа хүргэж зүрхэлсэнгүй. Эдүгээ тэд миний өмнө гандах болуузай хэмээх учир ийнхүү үйлдэж эс зүрхэлнэм, Бурханы Сүнс тийм хүчтэй байв; мөн энэ нь тэдэнд ийнхүү нөлөөлсөн буюу.

Behold, my soul is rent with anguish because of you, and my heart is pained; I fear lest ye shall be cast off forever. Behold, I am full of the Spirit of God, insomuch that my frame has no strength.

And now it came to pass that when I had spoken these words they were angry with me, and were desirous to throw me into the depths of the sea; and as they came forth to lay their hands upon me I spake unto them, saying: In the name of the Almighty God, I command you that ye touch me not, for I am filled with the power of God, even unto the consuming of my flesh; and whoso shall lay his hands upon me shall wither even as a dried reed; and he shall be as naught before the power of God, for God shall smite him.

And it came to pass that I, Nephi, said unto them that they should murmur no more against their father; neither should they withhold their labor from me, for God had commanded me that I should build a ship.

And I said unto them: If God had commanded me to do all things I could do them. If he should command me that I should say unto this water, be thou earth, it should be earth; and if I should say it, it would be done.

And now, if the Lord has such great power, and has wrought so many miracles among the children of men, how is it that he cannot instruct me, that I should build a ship?

And it came to pass that I, Nephi, said many things unto my brethren, insomuch that they were confounded and could not contend against me; neither durst they lay their hands upon me nor touch me with their fingers, even for the space of many days. Now they durst not do this lest they should wither before me, so powerful was the Spirit of God; and thus it had wrought upon them.

53 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Гараа ах нарынхаа зүг дахин сунга, мөн тэд чиний өмнө гандахгүй, харин би тэднийг цочрооно, мөн би бол Их Эзэн тэдний Бурхан мөнийг тэд мэдэж болохын тулд би үүнийг үйлдэх болно хэмээн Их Эзэн хэлэв.

54 Мөнхүү улиран тохиох дор би ах нарынхаа зүг гараа сунгавал, мөн тэд миний өмнө гандсангүй; харин Их Эзэн яг өөрийн хэлсэн тэрхүү үгийн дагуу тэднийг сэгсэрсэн буюу.

55 Мөн эдүгээ, тэд хэлэв: Бид Их Эзэн чамтай буйг гарцаагүй мэдлээ, учир нь биднийг сэгсэрсэн нь Их Эзэний хүч гэдгийг бид мэднэ. Мөн тэд миний өмнө унаж, мөн намайг бишрэн шүтэхийг завдав, гэвч би тэдэнд зөвшөөрсөнгүй, хэлсэн нь: Би бол та нарын дүү, тийм ээ, бүр насан бага дүү чинь; иймийн тул, Их Эзэн Бурханаа бишрэн шүт, мөн эцэг эхээ дээдлэн хүндэл, Их Эзэн Бурхан тань та нарт өгөх тэрхүү нутагт та нарын өдрүүд урт байж болохын тулд болой.

And it came to pass that the Lord said unto me: Stretch forth thine hand again unto thy brethren, and they shall not wither before thee, but I will shock them, saith the Lord, and this will I do, that they may know that I am the Lord their God.

And it came to pass that I stretched forth my hand unto my brethren, and they did not wither before me; but the Lord did shake them, even according to the word which he had spoken.

And now, they said: We know of a surety that the Lord is with thee, for we know that it is the power of the Lord that has shaken us. And they fell down before me, and were about to worship me, but I would not suffer them, saying: I am thy brother, yea, even thy younger brother; wherefore, worship the Lord thy God, and honor thy father and thy mother, that thy days may be long in the land which the Lord thy God shall give thee.

## 1 Нифай 18

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэнийг бишрэн шүтэж, мөн надтай хамтран одов; мөн бид дүнз модыг нямбайлан урнаар дархлав. Мөн Их Эзэн усан онгоцны дүнз модыг ямар маягаар бэлтгэхийг цагаас цагт надад үзүүлж байсан бөлгөө.
- 2 Эдүгээ би, Нифай, дүнз модыг хүмүүсээр сургагдсан тэр маягаар бэлтгэсэнгүй, хүмүүсийн барьдаг тийм маягаар ч усан онгоцыг би бас барьсангүй; харин би Их Эзэн надад үзүүлсэн тэр маягаар барьсан билээ; иймийн тул, энэ нь хүмүүсийнхтэй адил байсангүй.
- 3 Мөн би, Нифай, байн байн ууланд гарч, мөн би Их Эзэнд дахин дахин залбирсан бөлгөө; иймийн тул Их Эзэн надад агуу зүйлийг үзүүлэв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний үгийн дагуу усан онгоцыг би дуусгасны дараа, ах нар маань энэ нь сайн болсныг, мөн үүний ур хийц үлэмж сайн байсныг харсан бөлгөө; иймийн тул, тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө дахин даруусгав.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой эцэгт минь ирж, биднийг босч мөн усан онгоцонд очвол зохино хэмээв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор маргааш өдөр нь бид бүх зүйлийг, аглаг буйдаас ихээхэн жимс бас хүнс, мөн арвин их бал, мөн Их Эзэн бидэнд зарлигласны дагуу хоол хүнс бэлтгэсний дараа, бид өөрсдийн бүх ачаа мөн үр тариаг, мөн бид насны эрэмбээр, авчирсан бүх зүйлээ өөрсөддөө авч усан онгоцонд очив; иймийн тул, бид бүгд эхнэр болон хүүхдүүдийнхээ хамт усан онгоцонд очсон бөлгөө.
- 7 Мөн эдүгээ, эцэг минь аглаг буйдад хоёр хөвгүүнтэй болсон байв; ахмад нь Иаков, дүүмэд нь Иосеф хэмээгдэх бөлгөө.
- 8 Мөнхүү улиран тохиох дор бидэнд зарлиг болсон тэр зүйлүүд мөн хоол бид бүгд хүнсээ өөрсөддөө авч, усан онгоцонд очсоны дараа, бид тэнгист гарч, амлагдсан нутгийг зүглэн салхинд туугдан одов.

## 1 Nephi 18

And it came to pass that they did worship the Lord, and did go forth with me; and we did work timbers of curious workmanship. And the Lord did show me from time to time after what manner I should work the timbers of the ship.

Now I, Nephi, did not work the timbers after the manner which was learned by men, neither did I build the ship after the manner of men; but I did build it after the manner which the Lord had shown unto me; wherefore, it was not after the manner of men.

And I, Nephi, did go into the mount oft, and I did pray oft unto the Lord; wherefore the Lord showed unto me great things.

And it came to pass that after I had finished the ship, according to the word of the Lord, my brethren beheld that it was good, and that the workmanship thereof was exceedingly fine; wherefore, they did humble themselves again before the Lord.

And it came to pass that the voice of the Lord came unto my father, that we should arise and go down into the ship.

And it came to pass that on the morrow, after we had prepared all things, much fruits and meat from the wilderness, and honey in abundance, and provisions according to that which the Lord had commanded us, we did go down into the ship, with all our loading and our seeds, and whatsoever thing we had brought with us, every one according to his age; wherefore, we did all go down into the ship, with our wives and our children.

And now, my father had begat two sons in the wilderness; the elder was called Jacob and the younger Joseph.

And it came to pass after we had all gone down into the ship, and had taken with us our provisions and things which had been commanded us, we did put forth into the sea and were driven forth before the wind towards the promised land.

- 9 Мөн бид олон хоногийн турш салхинд туугдсаны дараа, болгоогтун, ах нар маань бас Ишмэлийн хөвгүүд мөн түүнчлэн тэдний эхнэрүүд өөрсдийгөө зугаацуулж эхлэв, үүний хэрээр тэд бүжиглэж мөн дуулж, бас ихэд балмадыг ярьж эхлэв, тийм ээ, бүр тэд хэний хүчээр тэнд авчрагдсанаа мартсан байв; тийм ээ, тэд үлэмж балмад явдалдаа хөөрөн байв.
- 10 Мөн би, Нифай, Их Эзэн бидэнд уурлаж, мөн алдсын маань улмаас биднийг цохьж тэгээд бид тэнгисийн гүнд үйх буюу хэмээн үлэмж айж эхлэв; иймийн тул, би, Нифай, тэдэнд ихэд буурь суурьтайгаар ярьж эхлэв; гэвч болгоогтун тэд надад уурлаж, хэлсэн нь: Бид дүүгээ өөрсдийн захирагч байлгахгүй хэмээв.
- 11 Мөнхүү улиран тохиох дор Лемен Лемүел хоёр намайг барьж мөн олсоор хүлээд, мөн тэд надад ихэд хэрцгийгээр хандав; гэсэн хэдий ч ёсон бусыг үйлдэгчдийн талаар түүний ярьсан үг гүйцэлдэхийн тулд, Их Эзэн өөрийн хүчийг үзүүлэхээр үүнийг үйлдэхийг тэвчсэн буюу.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэд намайг хүлж үүний хэрээр би хөдөлж чадахаа больсны дараа, Их Эзэн бэлтгэж өгсөн мөнөөх луужин ажиллахаа болив.
- 13 Иймийн тул, тэд усан онгоцыг хааш залахыг мэдсэнгүй, тэгтэл их салхи босох нь тэр, тийм ээ, агуу бөгөөд аймшигт хуй салхи, мөн бид усан дээгүүр гурав хоногийн турш буцаан туугдав; мөн далайд живэх болуузай хэмээн үлэмж айж эхлэв; гэсэн хэдий ч, тэд намайг сулласангүй.
- 14 Мөн бид буцаж туугдсаны дөрөв дэх өдөр, хуй салхи үлэмж ширүүн болж эхлэв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор бид бараг л далайн гүнд үйхийг шахав. Мөн бид дөрвөн өдрийн турш усан дээгүүр буцаж туугдсаны дараа, ах нар маань Бурханы шүүлт тэдний дээр байсныг, мөн тэд алдсаа наманчлахгүй аваас тэд эрсдэх ёстой гэдгийг сая ойлгож эхлэв; иймийн тул, тэд надад ирж, мөн миний бугуйн дахь хүлгийг суллан авав, мөн болгоогтун миний гарын хоёр бугуй үлэмж хавдсан байв; мөн түүнчлэн миний хөлийн шагай ч маш их хавдаж, хөндүүрлэх нь туйлын бэрх байлаа.

And after we had been driven forth before the wind for the space of many days, behold, my brethren and the sons of Ishmael and also their wives began to make themselves merry, insomuch that they began to dance, and to sing, and to speak with much rudeness, yea, even that they did forget by what power they had been brought thither; yea, they were lifted up unto exceeding rudeness.

And I, Nephi, began to fear exceedingly lest the Lord should be angry with us, and smite us because of our iniquity, that we should be swallowed up in the depths of the sea; wherefore, I, Nephi, began to speak to them with much soberness; but behold they were angry with me, saying: We will not that our younger brother shall be a ruler over us.

And it came to pass that Laman and Lemuel did take me and bind me with cords, and they did treat me with much harshness; nevertheless, the Lord did suffer it that he might show forth his power, unto the fulfilling of his word which he had spoken concerning the wicked.

And it came to pass that after they had bound me insomuch that I could not move, the compass, which had been prepared of the Lord, did cease to work.

Wherefore, they knew not whither they should steer the ship, insomuch that there arose a great storm, yea, a great and terrible tempest, and we were driven back upon the waters for the space of three days; and they began to be frightened exceedingly lest they should be drowned in the sea; nevertheless they did not loose me.

And on the fourth day, which we had been driven back, the tempest began to be exceedingly sore.

And it came to pass that we were about to be swallowed up in the depths of the sea. And after we had been driven back upon the waters for the space of four days, my brethren began to see that the judgments of God were upon them, and that they must perish save that they should repent of their iniquities; wherefore, they came unto me, and loosed the bands which were upon my wrists, and behold they had swollen exceedingly; and also mine ankles were much swollen, and great was the soreness thereof.

- 16 Гэсэн хэдий ч, би Бурхандаа найдаж, мөн би түүнийг бүхэл өдрийн турш магтан алдаршуулав; мөн би зовлон зүдгүүрүүдийнхээ учир Их Эзэний эсрэг бувтнасан нь үгүй билээ.
- 17 Эдүгээ миний эцэг, Лихай, тэдэнд мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүдэд олон зүйлийг хэлсэн байв; гэвч, болгоогтун, тэд миний төлөө ярьсан хэнийг боловч ихэд эсэргүүцэн сүрдүүлэв; мөн эцэг эх минь насанд дарагдан, мөн хүүхдүүдийнхээ улмаас уй гашуу болон шаналсны улмаас, дордож, тийм ээ, тэд бүр хэвтэрт оров.
- 18 Тэдний уй гашуу, их эмгэнэл, мөн ах нарын маань алдсын учир, тэд бүр энэ цагийг орхин одож Бурхантайгаа уулзахад ойрхон болсон байв; тийм ээ, тэдний буурал үс газар тавигдах болоод байв; тийм ээ, тэд бүр уйтгар гунигаа тээн усан булшинд орхигдоход ойрхон байлаа.
- 19 Мөн түүнчлэн Иаков Иосеф хоёр бага байж, халамж ихэд хэрэгтэй байснаас, эхийнхээ зовлон зүдгүүрүүдийн улмаас шаналж байв; мөн түүнчлэн эхнэрийн минь асгаруулах нулимс мөн залбирлууд бас түүнчлэн миний хүүхдүүдийнх ч, ах нарын минь сэтгэлийг тэд намайг чөлөөлөхөөр болтол зөөллөсөнгүй.
- 20 Мөн тэднийг устгалаар сүрдүүлэх Бурханы хүчнээс өөр тэдний зүрх сэтгэлийг зөөллөх юм юухан ч байсангүй; иймийн тул, тэд бараг далайн гүнд үйх гэж буйгаа хараад тэд үйлдсэн зүйлийнхээ төлөө наманчилж, тэгээд намайг суллав.
- 21 Мөнхүү улиран тохиох дор тэд намайг сулласны дараа, болгоогтун, би луужинг авав, мөн энэ нь миний хүссэнээр ажиллаж байв. Мөнхүү улиран тохиох дор би Их Эзэнд залбирав; тийнхүү намайг залбирсны дараа салхи зогсож, мөн шуурга номхров, тэгээд ихэд нам тайван болов.
- 22 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, усан онгоцыг удирдаж, бид амлагдсан нутгийг дахин чиглэв.
- 23 Мөнхүү улиран тохиох дор бид олон хоногийн турш хөвсний дараа бид амлагдсан нутагт хүрч ирэв; мөн бид урагш газар дээр гарч, майхнуудаа босгов; тэгээд бид үүнийг амлагдсан нутаг гэж нэрлэсэн бөлгөө.

Nevertheless, I did look unto my God, and I did praise him all the day long; and I did not murmur against the Lord because of mine afflictions.

Now my father, Lehi, had said many things unto them, and also unto the sons of Ishmael; but, behold, they did breathe out much threatenings against anyone that should speak for me; and my parents being stricken in years, and having suffered much grief because of their children, they were brought down, yea, even upon their sick-beds.

Because of their grief and much sorrow, and the iniquity of my brethren, they were brought near even to be carried out of this time to meet their God; yea, their grey hairs were about to be brought down to lie low in the dust; yea, even they were near to be cast with sorrow into a watery grave.

And Jacob and Joseph also, being young, having need of much nourishment, were grieved because of the afflictions of their mother; and also my wife with her tears and prayers, and also my children, did not soften the hearts of my brethren that they would loose me.

And there was nothing save it were the power of God, which threatened them with destruction, could soften their hearts; wherefore, when they saw that they were about to be swallowed up in the depths of the sea they repented of the thing which they had done, inso-much that they loosed me.

And it came to pass after they had loosed me, behold, I took the compass, and it did work whither I desired it. And it came to pass that I prayed unto the Lord; and after I had prayed the winds did cease, and the storm did cease, and there was a great calm.

And it came to pass that I, Nephi, did guide the ship, that we sailed again towards the promised land.

And it came to pass that after we had sailed for the space of many days we did arrive at the promised land; and we went forth upon the land, and did pitch our tents; and we did call it the promised land.

24 Мөнхүү улиран тохиох дор бид газар боловсруулж эхлэн, мөн бид үр тариагаа суулгаж эхлэв; тийм ээ, бид Иерусалим нутгаас авчирсан тэр бүх үрээ газарт суулгав. Мөнхүү улиран тохиох дор тэдгээр нь үлэмж сайн ургав; иймийн тул, бид элбэг дэлбэгээр адислагдав.

25 Мөнхүү улиран тохиох дор бид амлалтын нутагт, аглаг буйдад аялж байх зуур ойн бүх төрлийн араатан амьтад, үхэр болон шар аль аль нь, мөн илжиг ба морь, мөн ямаа ба зэрлэг ямаа, мөн бүх төрлийн зэрлэг амьтад, хүний хэрэгцээнд зориулагдсан байхыг олсон бөлгөө. Мөн бид алтны, бас мөнгөний, бас зэсийн хүдрийг бүх төрлөөр нь олов.

And it came to pass that we did begin to till the earth, and we began to plant seeds; yea, we did put all our seeds into the earth, which we had brought from the land of Jerusalem. And it came to pass that they did grow exceedingly; wherefore, we were blessed in abundance.

And it came to pass that we did find upon the land of promise, as we journeyed in the wilderness, that there were beasts in the forests of every kind, both the cow and the ox, and the ass and the horse, and the goat and the wild goat, and all manner of wild animals, which were for the use of men. And we did find all manner of ore, both of gold, and of silver, and of copper.



## 1 Нифай 19

- 1 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад зарлигласан бөлгөө, иймийн тул би хүмүүсийнхээ цэдгийг сийлж болохын тулд ялтсуудыг хийсэн бөлгөө. Мөн өөрийн хийсэн ялтсууд дээр би эцгийнхээ цэдгийг, мөн түүнчлэн аглаг буйд дахь бидний аян, мөн эцгийнхээ бошиглолуудыг сийлбэрлэв; мөн түүнчлэн би тэдгээрийн дээр өөрийн бошиглолуудаас олныг сийлсэн билээ.
- 2 Мөн би тэдгээрийг хийж байх үед Их Эзэн эдгээр ялтсуудыг хий хэмээн надад зарлиг болохыг мэдсэнгүй; иймийн тул, миний эцгийн цэдэг, мөн түүний өвөг дээдсийн удам судар, мөн аглаг буйд дахь бидний явдлуудын ихэнх нь миний ярьсан тэдгээр эхний ялтсууд дээр сийлбэрлэгдсэн билээ; иймийн тул, намайг эдгээр ялтсуудыг хийхээс урьд тохиолдсон тэдгээр зүйлүүд нь үнэхээр илүү нарийвчлалтайгаар эхний ялтсууд дээр дурдагдсан бөлгөө.
- 3 Мөн би эдгээр ялтсуудыг зарлигласнаар үйлдсэний дараа, би, Нифай, тохинуулал болон бошиглолуудын илүү тодорхой болон эрхэм үнэт хэсгүүдийг эдгээр ялтсууд дээр бичвэл зохино хэмээх зарлиг хүлээн авлаа; мөн бичигдсэн эдгээр зүйлүүд миний хүмүүст, уг нутгийг өвлөх тэдэнд заавар болж, мөн түүнчлэн бусад мэргэн зорилгууд, Их Эзэний мэдэх тэр зорилгуудын улмаас хадгалагдах бөлгөө.
- 4 Иймийн тул, би, Нифай, дайнууд болон зөрчилдөөнүүд мөн миний хүмүүсийн устгалуудын шастырыг өгүүлнэ, өөрөөр хэлбэл илүү дэлгэрэнгүй шастырыг өгсөн нөгөө ялтсууд дээр цэдгийг бичиглэв. Мөн би үүнийг хийж бас намайг явсны дараа тэд юу хийвэл зохихыг өөрийн хүмүүст зарлиг болгов; мөн эдгээр ялтсууд үеэс үед, өөрөөр хэлбэл нэг бошиглогчоос нөгөөд дамжин Их Эзэний цаашдын зарлигуудыг хүртэл байх буюу.
- 5 Мөн би эдгээр ялтсуудыг хийсэн тухай шастир хожим нь өгөгдөх болно; мөн тэгээд, болгоогтун, би ярьсныхаа дагуу үргэлжлүүлнэ; мөн бибээр үүнийг хийсний учир нь илүү эрхэм нандин зүйлүүд нь өөрийн хүмүүсийн мэдлэгийн тулд хадгалагдаж болно гэснийх бөлгөө.

## 1 Nephi 19

And it came to pass that the Lord commanded me, wherefore I did make plates of ore that I might engraven upon them the record of my people. And upon the plates which I made I did engraven the record of my father, and also our journeyings in the wilderness, and the prophecies of my father; and also many of mine own prophecies have I engraven upon them.

And I knew not at the time when I made them that I should be commanded of the Lord to make these plates; wherefore, the record of my father, and the genealogy of his fathers, and the more part of all our proceedings in the wilderness are engraven upon those first plates of which I have spoken; wherefore, the things which transpired before I made these plates are, of a truth, more particularly made mention upon the first plates.

And after I had made these plates by way of commandment, I, Nephi, received a commandment that the ministry and the prophecies, the more plain and precious parts of them, should be written upon these plates; and that the things which were written should be kept for the instruction of my people, who should possess the land, and also for other wise purposes, which purposes are known unto the Lord.

Wherefore, I, Nephi, did make a record upon the other plates, which gives an account, or which gives a greater account of the wars and contentions and destructions of my people. And this have I done, and commanded my people what they should do after I was gone; and that these plates should be handed down from one generation to another, or from one prophet to another, until further commandments of the Lord.

And an account of my making these plates shall be given hereafter; and then, behold, I proceed according to that which I have spoken; and this I do that the more sacred things may be kept for the knowledge of my people.

- 6 Гэсэн хэдий ч, би эрхэм нандин гэж бодсоноос бусдыг ялтсууд дээр нэгээхнийг ч бичиглэх нь үгүй. Мөн эдүгээ, хэрэв би алдаа гаргасан ахул, бүр урьд цагийн тэд ч бас алдаа гаргасан бөлгөө; бусадтай адилтган өөрийгөө би зөвтгөхгүй, харин махбодид оршсоны дагуу өөрт буй дутагдлаас өөрийгөө би зөвтгөнө.
- 7 Учир нь зарим хүмүүн махбодийн болон сүнсний аль алиных нь хувьд ихэд чухалчлан үнэлэх зүйлийг, бусад зарим нь үл ойшоож мөн хөл дороо дэвслэх ажгуу. Тийм ээ, бүр Израилын туйлын Бурханыг ч хүмүүс хөл дороо дэвслэх ажээ; би хэлнэ, хөл дороо дэвслэх гэхээс би өөр үгээр хэлье—тэд түүнийг үл ойшоож, мөн түүний зөвлөх дууг эс анхаарна.
- 8 Мөн болгоогтун тэнгэр элчийн үгсийн дагуу, миний эцэг Иерусалимыг орхисон цагаас зургаан зуун жилийн тэртээ тэрээр ирэх болно.
- 9 Мөн энэ дэлхийнхэн, алдсынхаа учир, гологдсон зүйл мэт түүнийг шүүх болно; иймийн тул тэд түүнийг ташуурдахад, мөн тэрээр үүнийг тэвчинэ; мөн тэд түүнийг цохиход, мөн тэрээр үүнийг тэвчинэ. Тийм ээ, тэд түүнийг нулимаж бөлгөө, мөн хүмүүний үрсийн зүг хандах өөрийн өгөөмөр хайр мөн өөрийн хүлцэнгүй гэсвэрлэлийн учир тэрээр үүнийг тэвчих болно.
- 10 Мөн бидний эцэг өвгөдийн, Египетээс боолчлоос удирдагдан гаргагдсан, мөн түүнчлэн аглаг буйдад түүгээр хамгаалагдсан тэдний Бурхан, тийм ээ, Абрахамын, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурхан, Зенокийн үгсийн дагуу дээш өргөгдөхөөр, мөн Неюмийн үгсийн дагуу цовдлогдохоор, мөн далайн арлуудад оршин суугч тэдэнд, ялангуяа Израилын угсааныхан болох тэдэнд өгөгдөх түүний үхлийн тэмдэг болох гурав хоногийн харанхуйн талаар ярьсан Зиносын үгсийн дагуу хадан булшинд оршуулагдахаар тэнгэр элчийн үгсийн дагуу, хүмүүний адилаар, ёсон бус хүмүүсийн гарт өөрийгөө өгөх болно.

Nevertheless, I do not write anything upon plates save it be that I think it be sacred. And now, if I do err, even did they err of old; not that I would excuse myself because of other men, but because of the weakness which is in me, according to the flesh, I would excuse myself.

For the things which some men esteem to be of great worth, both to the body and soul, others set at naught and trample under their feet. Yea, even the very God of Israel do men trample under their feet; I say, trample under their feet but I would speak in other words—they set him at naught, and hearken not to the voice of his counsels.

And behold he cometh, according to the words of the angel, in six hundred years from the time my father left Jerusalem.

And the world, because of their iniquity, shall judge him to be a thing of naught; wherefore they scourge him, and he suffereth it; and they smite him, and he suffereth it. Yea, they spit upon him, and he suffereth it, because of his loving kindness and his long-suffering towards the children of men.

And the God of our fathers, who were led out of Egypt, out of bondage, and also were preserved in the wilderness by him, yea, the God of Abraham, and of Isaac, and the God of Jacob, yieldeth himself, according to the words of the angel, as a man, into the hands of wicked men, to be lifted up, according to the words of Zenock, and to be crucified, according to the words of Neum, and to be buried in a sepulchre, according to the words of Zenos, which he spake concerning the three days of darkness, which should be a sign given of his death unto those who should inhabit the isles of the sea, more especially given unto those who are of the house of Israel.

- 11 Учир нь бошиглогч тийн ярив: тэр өдөр Их Эзэн Бурхан Израилын бүх угсааныханд заримд нь тэдний зөв шударгын учир тэрээр өөрийн дуу хоолойгоор тэдэнд агуу их баяр хөөр мөн аврал болж, мөн бусад заримд нь түүний хүч болох тэнгэрийн дуу мөн аянга цахилгаан, шуурга, түймэр, мөн утаа, мөн харанхуйлах манан, мөн газар нээгдэн хагарах, мөн өргөгдөн зөөгдөх уулсаар зочлох нь гарцаагүй болло.
- 12 Мөн эдгээр бүх зүйл гарцаагүй ирнэ гэдгийг бошиглогч Зинос хэлсэн билээ. Мөн газрын хад чулуу хагарах ёстой; мөн газар дэлхийн ёолох дуунаас Бурханы Сүнсний нөлөөн дор, далайн арлын хаадын олон нь: Хорвоогийн Бурхан зовж байна хэмээн уулга алдах болно.
- 13 Мөн Иерусалимд байгч тэдэнд зориулан, бошиглогч хэлсэнчлэн, тэд бүх хүмүүсээр цээрлүүлэгдэх болно, тэд Израилын Бурханыг цовдолж, мөн зүрх сэтгэлээ өөр зүг хандуулж, тэмдгүүд болон гайхамшгуудаас, мөн Израилын Бурханы суу билиг болон хүчийг эсэргүүцсэний учир бөлгөө.
- 14 Мөн тэд зүрх сэтгэлээ өөр зүг хандуулсны учир, бошиглогчийн хэлсэнчлэн, мөн Израилын Ариун Нэгэнийг гадуурхсаны учир, тэд энэ бие махбодид орших үедээ хэсэн бэдэрч, мөн шийтгэгдэж, мөн муугаар хэлэгдэн бас муугийн зүйр болон, мөн бүх үндэстний дунд үзэн ядагдах болно.
- 15 Гэсэн хэдий ч, бошиглогчийн хэлсэнчлэн тэд зүрх сэтгэлээ Израилын Ариун Нэгэний эсрэг өөр зүг дахин хандуулахгүй тэрхүү өдөр ирэхэд, тэгээд тэрээр тэдний эцэг өвгөдтэй хийсэн гэрээнүүдээ санах болно.
- 16 Тийм ээ, тэгээд тэрээр далайн арлуудыг санах болно; тийм ээ, мөн бошиглогч Зиносын үгсийн дагуу Израилын угсааны бүх хүмүүсийг би энэ дэлхийн дөрвөн зүгээс цуглуулах болно хэмээн Их Эзэн хэлэх ажгуу.
- 17 Тийм ээ, мөн бүх дэлхий Их Эзэний авралыг үзэх болно хэмээн бошиглогч хэлсэнчлэн; бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс адислагдах болно.

For thus spake the prophet: The Lord God surely shall visit all the house of Israel at that day, some with his voice, because of their righteousness, unto their great joy and salvation, and others with the thunders and the lightnings of his power, by tempest, by fire, and by smoke, and vapor of darkness, and by the opening of the earth, and by mountains which shall be carried up.

And all these things must surely come, saith the prophet Zenos. And the rocks of the earth must rend; and because of the groanings of the earth, many of the kings of the isles of the sea shall be wrought upon by the Spirit of God, to exclaim: The God of nature suffers.

And as for those who are at Jerusalem, saith the prophet, they shall be scourged by all people, because they crucify the God of Israel, and turn their hearts aside, rejecting signs and wonders, and the power and glory of the God of Israel.

And because they turn their hearts aside, saith the prophet, and have despised the Holy One of Israel, they shall wander in the flesh, and perish, and become a hiss and a byword, and be hated among all nations.

Nevertheless, when that day cometh, saith the prophet, that they no more turn aside their hearts against the Holy One of Israel, then will he remember the covenants which he made to their fathers.

Yea, then will he remember the isles of the sea; yea, and all the people who are of the house of Israel, will I gather in, saith the Lord, according to the words of the prophet Zenos, from the four quarters of the earth.

Yea, and all the earth shall see the salvation of the Lord, saith the prophet; every nation, kindred, tongue and people shall be blessed.

- 18 Мөн би, Нифай, эдгээр зүйлийг өөрийн хүмүүст хандан бичиглэсэн болой, би тэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчийг санахад ятган итгүүлж болох магад хэмээнэ.
- 19 Иймийн тул, хэрэв тэд эдгээр зүйлийг олж авах аваас би Израилын бүх угсааныханд ярих буюу.
- 20 Учир нь болгоогтун, Иерусалим дахь тэдний төлөө өөрийгөө цуцтал, бүр үе мөчөө сульдтал оюун сэтгэлдээ догдолно би; учир нь Их Эзэн бүр хуучны бошиглогчдод үзүүлснийхээ нэгэн адил надад тэдний талаар үзүүлж нигүүлсэнгүй байгаагүй бол би ч түүнчлэн эрсдэх байсан биз ээ.
- 21 Мөн тэрээр хуучны бошиглогчдод тэдний талаар бүх зүйлийг үзүүлсэн нь гарцаагүй; мөн түүнчлэн тэрээр бидний талаар олонд үзүүлсэн билээ; иймийн тул, тэдгээр нь гуулин ялтсууд дээр бичиглэгдсэний учир бид тэдний талаар мэдэх нь зайлшгүй бөлгөө.
- 22 Эдүгээ улиран тохиох дор би, Нифай, эдгээр зүйлийг ах нартаа сургав; мөнхүү улиран тохиох дор урьд цагийн хүмүүсийн дундах, өөр нутгууд дахь Их Эзэний үйлүүдийн талаар тэд мэдэж болохын тулд гуулин ялтсууд дээр сийлэгдсэн байсан, олон зүйлийг би тэдэнд уншиж бөлгөө.
- 23 Мөн би Мосегийн номнуудад бичигдсэн байсан тэр олон зүйлийг тэдэнд уншиж өгсөн болой; гэвч би тэднийг Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчид итгэхийг илүү бүрэн дүүрнээр ятгаж болно хэмээн би тэдэнд бошиглогч Исаиагийн бичиглэснийг уншиж өгөв; учир нь энэ нь бидэнд эрдэм болон тус байж болохын тулд би бүх судрыг өөрсөдтэйгөө адилтгасан билээ.
- 24 Иймийн тул би тэдэнд хандан ярьж, өгүүлсэн нь: Израилын угсааны үлдэгдэл, хугарсан мөчрүүд болох та нар бошиглогчийн үгсийг сонс; Израилын бүх угсаанд бичигдсэн бошиглогчдын үгсийг сонс, мөн та нарын тэднээс салгагдсан ах дүүсийнхээ нэгэн адил та нар найдлага агуулж болохын тулд тэдгээр үгсийг өөрсөдтэйгөө адилтган үз; учир нь иймэрхүү маягаар бошиглогч бичиглэсэн болой.

And I, Nephi, have written these things unto my people, that perhaps I might persuade them that they would remember the Lord their Redeemer.

Wherefore, I speak unto all the house of Israel, if it so be that they should obtain these things.

For behold, I have workings in the spirit, which doth weary me even that all my joints are weak, for those who are at Jerusalem; for had not the Lord been merciful, to show unto me concerning them, even as he had prophets of old, I should have perished also.

And he surely did show unto the prophets of old all things concerning them; and also he did show unto many concerning us; wherefore, it must needs be that we know concerning them for they are written upon the plates of brass.

Now it came to pass that I, Nephi, did teach my brethren these things; and it came to pass that I did read many things to them, which were engraven upon the plates of brass, that they might know concerning the doings of the Lord in other lands, among people of old.

And I did read many things unto them which were written in the books of Moses; but that I might more fully persuade them to believe in the Lord their Redeemer I did read unto them that which was written by the prophet Isaiah; for I did liken all scriptures unto us, that it might be for our profit and learning.

Wherefore I spake unto them, saying: Hear ye the words of the prophet, ye who are a remnant of the house of Israel, a branch who have been broken off; hear ye the words of the prophet, which were written unto all the house of Israel, and liken them unto yourselves, that ye may have hope as well as your brethren from whom ye have been broken off; for after this manner has the prophet written.

## 1 Нифай 20

- 1 Сонсоцгоо мөн үүнийг анхаар, ай Иаковын угсаа, Израилын нэрээр нэрлэгдсэн, мөн Иудейн уснаас, өөрөөр хэлбэл баптисмын уснаас гарч ирсэн та нар, Их Эзэний нэрээр тангараглах, мөн Израилын Бурханыг дурдах та нар, тийм хэдий ч тэд үнэнээр бус тангарагладаг бас зөв шударгаар ч бус болой.
- 2 Гэсэн хэдий ч, тэд өөрсдийгөө ариун хотынхон гэж нэрлэдэг, гэвч тэд өөрсдөө Израилын Бурханд, Түмний Их Эзэн түүнд тулгуурладаггүй; тийм ээ, Түмний Их Эзэн гэж түүний нэр болой.
- 3 Болгоогтун, би урьдын зүйлийг эхлэлээс тунхагласан болой; мөн тэдгээр нь миний амнаас гарч, мөн би тэдгээрийг үзүүлсэн бөлгөө. Би тэдгээрийг гэнэтхэн үзүүлсэн билээ.
- 4 Мөн би үүнийг хийсэн учир нь би та нарын гөжүүдийг, мөн та нарын хүзүү төмөр шөрмөс, мөн та харын магнай гуулин гэдгийг мэддэг байлаа.
- 5 Мөн би бүр эхлэлээс та нарт тунхагласаар ирсэн; энэ нь улиран тохиохоос урьд би та нарт тэдгээрийг үзүүлсэн; мөн та нар—Миний хиймэл шүтээн тэдгээрийг хийсэн, мөн миний зормол дүрс, мөн миний цутгамал дүрс тэдгээрийг зарлигласан гэж хэлэх болуузай хэмээн эмээсэн учир би тэдгээрийг үзүүлсэн юм.
- 6 Та нар энэ бүхнийг харж бас сонссон билээ; мөн та нар тэдгээрийг тунхаглахгүй гэж үү? Мөн би та нарт энэ цагийн шинэ зүйлийг, бүр далдлагдсан зүйлийг үзүүлсэн, мөн та нар тэдгээрийг мэдээгүй байсан буюу.
- 7 Тэдгээр нь эдүгээ бүтээгдсэн, мөн эхлэлээс бус, бүр та тэдгээрийг сонсоогүй тэр өдрөөс өмнө тэдгээр нь танд тунхаглагдсан, таныг—Болгоогтун би тэдгээрийг мэдсэн хэмээн хэлүүлэхгүйн тул буюу.
- 8 Тийм ээ, мөн та нар сонссон нь үгүй; тийм ээ, та нар мэдсэн нь үгүй; тийм ээ, тэр цагаас сонор тань нээгдээгүй байлаа; учир нь би та нарын ихэд итгэл эвдэн үйлдэхийг, мөн хэвлийд байхаасаа зөрчигч хэмээн нэрлэгдсэнийг мэдсэн билээ.
- 9 Гэсэн хэдий ч, өөрийн алдар суугийн төлөө би өөрийн хилэнг саатуулан, мөн өөрийгөө магтуулахын тулд би та нарыг тусгаарлахгүй гэвч инэ.

## 1 Nephi 20

Hearken and hear this, O house of Jacob, who are called by the name of Israel, and are come forth out of the waters of Judah, or out of the waters of baptism, who swear by the name of the Lord, and make mention of the God of Israel, yet they swear not in truth nor in righteousness.

Nevertheless, they call themselves of the holy city, but they do not stay themselves upon the God of Israel, who is the Lord of Hosts; yea, the Lord of Hosts is his name.

Behold, I have declared the former things from the beginning; and they went forth out of my mouth, and I showed them. I did show them suddenly.

And I did it because I knew that thou art obstinate, and thy neck is an iron sinew, and thy brow brass;

And I have even from the beginning declared to thee; before it came to pass I showed them thee; and I showed them for fear lest thou shouldst say—Mine idol hath done them, and my graven image, and my molten image hath commanded them.

Thou hast seen and heard all this; and will ye not declare them? And that I have showed thee new things from this time, even hidden things, and thou didst not know them.

They are created now, and not from the beginning, even before the day when thou heardest them not they were declared unto thee, lest thou shouldst say—Behold I knew them.

Yea, and thou heardest not; yea, thou knewest not; yea, from that time thine ear was not opened; for I knew that thou wouldst deal very treacherously, and wast called a transgressor from the womb.

Nevertheless, for my name's sake will I defer mine anger, and for my praise will I refrain from thee, that I cut thee not off.

10 Учир нь болгоогтун, би чамайг цэвэршүүлсэн, би чамайг зовлон зүдгүүрийн зууханд сонгосон бөлгөө.

11 Миний өөрийн тусын тулд, тийм ээ, миний өөрийн тусын тулд би үүнийг хийнэ, учир нь миний нэр гутаагдахыг би үл тэвчинэ, мөн би өөрийн алдар сууг өөр нэгэнд өгөхгүй.

12 Намайг сонсоцгоо, ай Иаков, мөн миний дуудсан Израил, учир нь би бол тэр; би бол эхнийх, мөн түүнчлэн би бол эцсийнх.

13 Миний мутар түүнчлэн дэлхийн суурийг тавьсан юм, мөн миний баруун мутар тэнгэр хурмастыг асарласан бөлгөө. Би тэдэнд дуудан хэлж мөн тэд нэгдэн тогтох болно.

14 Та нар бүгд, чуулан цуглар, мөн сонс; хэн тэдний дунд байж эдгээр зүйлийг тэдэнд тунхагласан билээ? Их Эзэн түүнийг хайрласан; тийм ээ, мөн тэрээр тэднээр тунхаглуулсан өөрийн үгийг тэр гүйцэлдүүлэх болно; мөн тэрээр Вавилонд өөрийн тааллаар үйлдэж, мөн түүний мутар халдейчууд дээр ирэх болно.

15 Түүнчлэн, Их Эзэн хэлнэ; би Их Эзэн, тийм ээ, би ярьсан; тийм ээ, би тунхаглуулахын тул түүнийг дуудсан билээ, би түүнийг авчирсан, мөн тэрээр түүний замыг дэвжих болгоно.

16 Та нар надад ойртон ир; би далдуур ярьсангүй; эхлэлээс, үүний тунхаглагдсан тэр цагаас би ярьсан; мөн Их Эзэн Бурхан, мөн түүний Сүнс намайг илгээсэн бөлгөө.

17 Мөн Их Эзэн, чиний Гэтэлгэгч, Израилын Ариун Нэгэн хэлэв; би түүнийг илгээсэн, Их Эзэн чиний Бурхан тусыг олохыг чамд сургасан тэр, чиний явбал зохих тэр замаар чамайг удирдах тэрбээр, үүнийг үйлдсэн бөлгөө.

18 Ай чи миний зарлигуудыг дуулсан болоосой —тэгсэн бол амар амгалан чинь гол мэт, мөн зөв шударга далайн давалгаа мэт байхсан буюу.

19 Чиний үр удам түүнчлэн элсний ширхэг мэт байхсан; биеэс тасрах үр удам чинь далайн хайрга чулуу мэт байхсан; түүний нэр миний өмнө арилгагдах учиргүй, устгагдах ч үгүй болой.

For, behold, I have refined thee, I have chosen thee in the furnace of affliction.

For mine own sake, yea, for mine own sake will I do this, for I will not suffer my name to be polluted, and I will not give my glory unto another.

Hearken unto me, O Jacob, and Israel my called, for I am he; I am the first, and I am also the last.

Mine hand hath also laid the foundation of the earth, and my right hand hath spanned the heavens. I call unto them and they stand up together.

All ye, assemble yourselves, and hear; who among them hath declared these things unto them? The Lord hath loved him; yea, and he will fulfil his word which he hath declared by them; and he will do his pleasure on Babylon, and his arm shall come upon the Chaldeans.

Also, saith the Lord; I the Lord, yea, I have spoken; yea, I have called him to declare, I have brought him, and he shall make his way prosperous.

Come ye near unto me; I have not spoken in secret; from the beginning, from the time that it was declared have I spoken; and the Lord God, and his Spirit, hath sent me.

And thus saith the Lord, thy Redeemer, the Holy One of Israel; I have sent him, the Lord thy God who teacheth thee to profit, who leadeth thee by the way thou shouldst go, hath done it.

O that thou hadst hearkened to my commandments—then had thy peace been as a river, and thy righteousness as the waves of the sea.

Thy seed also had been as the sand; the offspring of thy bowels like the gravel thereof; his name should not have been cut off nor destroyed from before me.

- 20 Та нар Вавилоноос яв, та нар халдейчуудаас зугт, та нар магтан дуулах дуугаар тунхагла, дэлхийн хязгаарт сонсго, үүнийг хэл; та нар: Их Эзэн өөрийн зарц Иаковыг гэтэлгэв хэмээн хэлэх буюу.
- 21 Мөн тэд цангасан нь үгүй; тэрээр тэднийг цөлийг гаталган удирдсан; тэдний төлөө тэрээр хаднаас ус үерлүүлсэн; тэрээр түүнчлэн хадыг хагалахад ус асгарсан билээ.
- 22 Мөн тэрээр энэ бүгдийг, мөн түүнчлэн илүү агуу хийсэн хэдий ч, Их Эзэн хэлсэнчлэн, ёсон бусыг үйлдэгчдэд амар амгалан үгүй болой.

Go ye forth of Babylon, flee ye from the Chaldeans, with a voice of singing declare ye, tell this, utter to the end of the earth; say ye: The Lord hath redeemed his servant Jacob.

And they thirsted not; he led them through the deserts; he caused the waters to flow out of the rock for them; he clave the rock also and the waters gushed out.

And notwithstanding he hath done all this, and greater also, there is no peace, saith the Lord, unto the wicked.

## 1 Нифай 21

- 1 Мөн үүнчлэн: Анхаарцгаа, Ай Израилын угсааныхан та нар, миний хүмүүсийн хоньчдын ёсон бус үйлүүдийн улмаас салгагдсан мөн зайлуулагдсан та нар бүгд; тийм ээ, салгагдсан, энгээр нэг тараагдсан миний хүмүүсийнх болох та нар бүгд, Ай Израилын угсаа. Анхаар, Ай арлууд, хүмүүс ээ та нар холоос анхаарцгаа, намайг; Их Эзэн намайг хэвлийд байхад дуудсан билээ; эхийнхээ хэвлийд байхаас тэр миний нэрийг дурдсан бөлгөө.
- 2 Мөн тэрээр миний амыг хурц илд мэт болгосон; тэр гарынхаа сүүдэрт намайг халхалж, мөн намайг өнгөлсөн сум мэт болгосон; тэр саадагтаа намайг далдалсан;
- 3 Мөн тэр надад хэлэв: Чи бол миний үйлчлэгч, Ай Израил, би бол алдар суу дуурсгуулах тэр буюу.
- 4 Тэгээд би хэлэв, би дэмий хөдөлмөрлөсөн, би хүчээ юунд ч үгүй дэмий зүйлд үрсэн; миний шүүлт Их Эзэнтэй хамт, мөн миний ажил миний Бурхантай хамт байгаа нь гарцаагүй буюу.
- 5 Мөн эдүгээ Их Эзэн хэлэв—хэвлийд байхаас нь Иаковыг түүнд буцааж авчрахын тулд өөрийн үйлчлэгч байхаар намайг бүрдүүлсэн тэр—Израил цуглуулагдаагүй байгаа хэдий ч, гэсэн ч би Их Эзэний мэлмийд алдарших болно, мөн миний Бурхан миний хүч байх болно.
- 6 Мөн тэр хэлэв: Иаковын овгуудыг тодруулахад, мөн Израилын хамгаалагдагсдыг сэргээхэд чи миний үйлчлэгч байх нь амархан зүйл. Би түүнчлэн дэлхийн хязгааруудад миний аврал нь чи байж болохын тулд, харийнханд гэрэл болгон чамайг би өгөх болно.
- 7 Тийн Их Эзэн, Израилын Гэтэлгэгч, түүний Ариун Нэгэн, хүмүүнд гадуурхагдах түүнд, үндэстнүүдэд жигшигдэх түүнд, захирагчдын үйлчлэгчид: үнэнч Их Эзэний учир, хаад хараад бас босох болно, хунтайжууд түүнчлэн бишрэн шүтэх болно хэмээн хэлэв.

## 1 Nephi 21

And again: Harken, O ye house of Israel, all ye that are broken off and are driven out because of the wickedness of the pastors of my people; yea, all ye that are broken off, that are scattered abroad, who are of my people, O house of Israel. Listen, O isles, unto me, and hearken ye people from far; the Lord hath called me from the womb; from the bowels of my mother hath he made mention of my name.

And he hath made my mouth like a sharp sword; in the shadow of his hand hath he hid me, and made me a polished shaft; in his quiver hath he hid me;

And said unto me: Thou art my servant, O Israel, in whom I will be glorified.

Then I said, I have labored in vain, I have spent my strength for naught and in vain; surely my judgment is with the Lord, and my work with my God.

And now, saith the Lord—that formed me from the womb that I should be his servant, to bring Jacob again to him—though Israel be not gathered, yet shall I be glorious in the eyes of the Lord, and my God shall be my strength.

And he said: It is a light thing that thou shouldst be my servant to raise up the tribes of Jacob, and to restore the preserved of Israel. I will also give thee for a light to the Gentiles, that thou mayest be my salvation unto the ends of the earth.

Thus saith the Lord, the Redeemer of Israel, his Holy One, to him whom man despiseth, to him whom the nations abhorreth, to servant of rulers: Kings shall see and arise, princes also shall worship, because of the Lord that is faithful.



- 8 Тийн Их Эзэн хэлэв: Тохиромжтой цагт би та нарыг сонссон, Ай далайн арлууд, мөн авралын өдөр би та нарт тусалсан билээ; мөн би чамайг хамгаалж, мөн хүмүүсийн гэрээ болгон өөрийн үйлчлэгчийг та нарт өгөх, дэлхийг тогтоох, эзэнгүй өвүүдийг өвлүүлэхийн тулд бөлгөө.
- 9 Та нар хоригдлуудад: Урагш од; харанхуйд суугчдад: Өөрсдийгөө үзүүл хэмээн хэлж болохын тулд бөлгөө. Тэд замуудаараа идэшлэх болно, мөн тэдний бэлчээр бүхий л өндөр газруудад байх болно.
- 10 Тэд өлсөхгүй бас цангах ч үгүй, мөн халуунд бас наранд цохиулахгүй; учир нь тэдний дээр нигүүлслийг хайрлах тэрээр тэднийг удирдах болно, бүр тэрээр усны ундаргаар тэднийг дагуулах болно.
- 11 Мөн би өөрийн бүх уулсыг зам болгож, мөн миний их хөлийн замууд өргөмжлөгдөх болно.
- 12 Мөн тэгээд, Ай Израилын угсааныхан, болгоогтун, эдгээр нь холоос ирэх болно; мөн үз, эдгээр нь умардаас мөн өрнөдөөс; мөн эдгээр нь Синимийн нутгаас ирэх болно.
- 13 Дуул, Ай тэнгэр; мөн баяс, Ай дэлхий; учир нь дорнодод байгчдын хөл тогтоогдох болой; мөн дуулцгаа, Ай уулс; учир нь тэд дахин нэгээхэн ч цохигдохгүй; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулж мөн өөрийн зовж зүдрэгсдийн дээр нигүүлслийг хайрлах болно.
- 14 Гэвч, болгоогтун, Сион ийн хэлдэг: Их Эзэн намайг орхисон, мөн миний Их Эзэн намайг мартсан гэдэг—гэвч тэрээр тэгээгүй гэдгээ өөрөө үзүүлэх болно.
- 15 Учир нь бүсгүй хүн хөхүүл хүүхдээ мартаж, хэвлийнээсээ унасан хүүгээ тэр өрөвдөн хайрлахгүй байж чадна гэж үү? Тийм ээ, тэд мартаж болох юм, гэвч би чамайг мартаж нь үгүй, Ай Израилын угсаа.
- 16 Болгоогтун, би та нарыг гарынхаа алган дээр сийлсэн; таны хананууд миний өмнө үргэлж байх бөлгөө.
- 17 Та нарын хүүхдүүд та нарыг устгагчдын эсрэг яарах болно; мөн чамайг балгас болгосон тэд чамаас явах болно.

Thus saith the Lord: In an acceptable time have I heard thee, O isles of the sea, and in a day of salvation have I helped thee; and I will preserve thee, and give thee my servant for a covenant of the people, to establish the earth, to cause to inherit the desolate heritages;

That thou mayest say to the prisoners: Go forth; to them that sit in darkness: Show yourselves. They shall feed in the ways, and their pastures shall be in all high places.

They shall not hunger nor thirst, neither shall the heat nor the sun smite them; for he that hath mercy on them shall lead them, even by the springs of water shall he guide them.

And I will make all my mountains a way, and my highways shall be exalted.

And then, O house of Israel, behold, these shall come from far; and lo, these from the north and from the west; and these from the land of Sinim.

Sing, O heavens; and be joyful, O earth; for the feet of those who are in the east shall be established; and break forth into singing, O mountains; for they shall be smitten no more; for the Lord hath comforted his people, and will have mercy upon his afflicted.

But, behold, Zion hath said: The Lord hath forsaken me, and my Lord hath forgotten me—but he will show that he hath not.

For can a woman forget her sucking child, that she should not have compassion on the son of her womb? Yea, they may forget, yet will I not forget thee, O house of Israel.

Behold, I have graven thee upon the palms of my hands; thy walls are continually before me.

Thy children shall make haste against thy destroyers; and they that made thee waste shall go forth of thee.

18 Нүдээ өргөн хараа бэлчээж мөн болгоогтун; эдгээр бүгд өөрсдөө нэгдэн цугларч, мөн тэд чамд ирэх болно. Мөн би амьдын адил, Их Эзэн хэлдэг, чи тэр бүгдээр өөрийгөө хувцаслаж, гоёж чимэх мэтээр, мөн тэднийг агуулж бүр хуримын бэр мэт байх нь гарцаагүй бөлгөө.

19 Учир нь, та нарын балгас мөн чиний эзгүйрсэн газрууд, мөн устгалын нутаг, бүр эдүгээ оршин суугчдад дэндүү давчуухан байх болно; мөн чамайг залгисан тэд алс хол байх болно.

20 Чи эхнийхийгээ алдсаны дараа, чиний төрүүлэх хүүхдүүд, чихэнд чинь дахин: Уг газар надад дэндүү давчуу байна; миний оршиж болох тэр газрыг надад өг хэмээн хэлэх болно.

21 Тэгээд чи өөрийн зүрхэндээ: Эдний эцэг нь хэн байсан билээ, харсаар би хүүхдүүдээ алдсан мөн хаягдмал, олзлогдмол, мөн нааш цааш нүүдэллэгч байсан бус уу? Мөн хэн эднийг өсгөн хүмүүжүүлэв? Болгоогтун, би ганцаар орхигдсон байсан, эд тэд хаана байсан бэ? хэмээн хэлэх бөлгөө.

22 Их Эзэн Бурхан тийн хэлэв: Болгоогтун, би мутраа харийнханд өргөх болно, мөн хүмүүст өөрийн далбааг өргөнө; мөн тэд чиний хөвгүүдийг гар дээрээ авчрах болно, мөн чиний охид тэдний мөрөн дээр зөөгдөх болно.

23 Мөн хаад та нарын асрагч эцэг, мөн тэдний хатад та нарын асрагч эх болно; тэд нүүрээ газарт хандуулан та нарт доош бөхийж, мөн та нарын хөлийн тоосыг долоох болно; мөн би бол Их Эзэн гэдгийг та нар мэдэх болно; учир нь намайг хүлээх тэд ичихгүй байх болно.

24 Учир нь, чадалтай нэгний олз булаагдан авагдаж, эсвэл хууль ёсоор боолчлогдсон тэд чөлөөлөгдөх үү

25 Харин Их Эзэн тийн хэлэв, бүр хүчтэй нэгэнд олзлогдогсод ч авагдах болно, мөн аймшигт нэгний идэш чөлөөлөгдөх болно; учир нь чамтай тэрслэгч түүнтэй би ч бас тэрслэх болно, мөн би хүүхдүүдийг чинь аврах болно.

26 Мөн өөрсдийнх нь биесээр чамд дарамт бологч тэднийг би тэжээх болно; тэд амтат дарсанд лугаа адил цусандаа согтох болно; мөн би, Их Эзэн, чиний Аврагч мөн чиний Гэтэлгэгч, Иаковын Хүчит Нэгэн гэдгийг бүх маханбодь мэдэх болно.

Lift up thine eyes round about and behold; all these gather themselves together, and they shall come to thee. And as I live, saith the Lord, thou shalt surely clothe thee with them all, as with an ornament, and bind them on even as a bride.

For thy waste and thy desolate places, and the land of thy destruction, shall even now be too narrow by reason of the inhabitants; and they that swallowed thee up shall be far away.

The children whom thou shalt have, after thou hast lost the first, shall again in thine ears say: The place is too strait for me; give place to me that I may dwell.

Then shalt thou say in thine heart: Who hath begotten me these, seeing I have lost my children, and am desolate, a captive, and removing to and fro? And who hath brought up these? Behold, I was left alone; these, where have they been?

Thus saith the Lord God: Behold, I will lift up mine hand to the Gentiles, and set up my standard to the people; and they shall bring thy sons in their arms, and thy daughters shall be carried upon their shoulders.

And kings shall be thy nursing fathers, and their queens thy nursing mothers; they shall bow down to thee with their face towards the earth, and lick up the dust of thy feet; and thou shalt know that I am the Lord; for they shall not be ashamed that wait for me.

For shall the prey be taken from the mighty, or the lawful captives delivered?

But thus saith the Lord, even the captives of the mighty shall be taken away, and the prey of the terrible shall be delivered; for I will contend with him that contendeth with thee, and I will save thy children.

And I will feed them that oppress thee with their own flesh; they shall be drunken with their own blood as with sweet wine; and all flesh shall know that I, the Lord, am thy Savior and thy Redeemer, the Mighty One of Jacob.

## 1 Нифай 22

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор би, Нифай, гуулин ялтсууд дээр сийлэгдсэн эдгээр зүйлийг уншсаны дараа, миний ах нар надад ирж мөн надад хэлэв: Чиний уншсан эдгээр зүйлүүд ямар утгатай билээ? Болгоогтун, тэдгээр нь махбодиор биш харин сүнсээр улиран тохиох тэрхүү сүнслэг зүйлүүдийн дагуу ойлгогдох уу
- 2 Мөн би, Нифай, тэдэнд хэлсэн нь: Болгоогтун тэдгээр нь Сүнсний дуу хоолойгоор бошиглогчдод илчлэгдсэн буюу; учир нь махан бодийн дагуу хүмүүний үрсийн дээр ирэх тэр бүх зүйлүүд Сүнсээр бошиглогчдод мэдүүлэгддэг бөлгөө.
- 3 Иймийн тул, миний уншсан тэдгээр зүйлүүд зуурдын болон сүнслэг аль алинд нь хамаарах зүйлүүд; учир нь энэхүү Израилын угсаа эрт орой нэгэн цагт, бүх дэлхийн гадаргуугаар мөн түүнчлэн бүх үндэстний дунд тараагдсан мэт харагдана.
- 4 Мөн болгоогтун, Иерусалим дахь тэдгээрийн мэдлэгээс аль хэдийнэ алдуурсан нь олон буй. Тийм ээ, бүх овгуудын ихэнх хэсэг нь гадагш удирдагдсан байгаа; мөн тэд далайн арлууд дээгүүр энд тэндгүй тараагдсан болой; мөн бид тэдний гадагш удирдагдсаныг мэдэхээс бус, бидний нэг нь ч тэдний хаана буйг үл мэднэ.
- 5 Мөн тэд гадагш удирдагдсанаас хойш, тэдний талаар, мөн түүнчлэн Израилын Ариун Нэгэний учир, хойшид тараагдах тэд бүхний талаар эдгээр зүйлс бошиглогдсон буй; учир нь тэд түүний эсрэг зүрхээ хатууруулах болно; иймийн тул, тэд бүх үндэстний дунд тараагдах болно мөн бүх хүмүүсээр үзэн ядагдах болно.
- 6 Гэсэн хэдий ч, тэд харийнханаар асруулж, мөн Их Эзэн мутраа харийнханы дээр өргөж мөн тэднийг далбаа болгон өргөж, мөн тэдний хүүхдүүд тэдний гарт зөөгдөж, мөн тэдний охид тэдний мөрөн дээр зөөгдсөний дараа, эдгээр яригдсан зүйлүүд бол зуурдынх гэдгийг болгоогтун; учир нь бидний өвөг дэдэстэй Их Эзэний хийсэн гэрээнүүд ийм буюу; мөн энэ нь ирэх өдрүүдэд биднийг, мөн түүнчлэн Израилын угсааны бидний бүх ах дүүсийг илэрхийлэх бөлгөө.

## 1 Nephi 22

And now it came to pass that after I, Nephi, had read these things which were engraven upon the plates of brass, my brethren came unto me and said unto me: What meaneth these things which ye have read? Behold, are they to be understood according to things which are spiritual, which shall come to pass according to the spirit and not the flesh?

And I, Nephi, said unto them: Behold they were manifest unto the prophet by the voice of the Spirit; for by the Spirit are all things made known unto the prophets, which shall come upon the children of men according to the flesh.

Wherefore, the things of which I have read are things pertaining to things both temporal and spiritual; for it appears that the house of Israel, sooner or later, will be scattered upon all the face of the earth, and also among all nations.

And behold, there are many who are already lost from the knowledge of those who are at Jerusalem. Yea, the more part of all the tribes have been led away; and they are scattered to and fro upon the isles of the sea; and whither they are none of us knoweth, save that we know that they have been led away.

And since they have been led away, these things have been prophesied concerning them, and also concerning all those who shall hereafter be scattered and be confounded, because of the Holy One of Israel; for against him will they harden their hearts; wherefore, they shall be scattered among all nations and shall be hated of all men.

Nevertheless, after they shall be nursed by the Gentiles, and the Lord has lifted up his hand upon the Gentiles and set them up for a standard, and their children have been carried in their arms, and their daughters have been carried upon their shoulders, behold these things of which are spoken are temporal; for thus are the covenants of the Lord with our fathers; and it meaneth us in the days to come, and also all our brethren who are of the house of Israel.

- 7 Мөн бүх Израилын угсаа бусниулагдан мөн тараагдсаны дараа, Их Эзэн Бурхан хүчирхэг үндэстнийг харийнханы дунд босгох цаг ирэх болно, тийм ээ, бүр энэ нутгийн гадаргуу дээр; мөн тэднээр бидний үр удам тараагдах болно.
- 8 Мөн бидний үр удам тараагдсаны дараа Их Эзэн Бурхан харийнханы дунд бидний үр удамд агуу үнэтэй болох гайхамшигт ажлыг хийхээр зорих болно; иймийн тул, энэ нь тэд харийнханаар асруулж мөн тэдний гарт мөн тэдний мөрөн дээр зөөгдөхтэй адилтгагдах буюу.
- 9 Мөн түүнчлэн энэ нь харийнханд үнэтэй байх болно; мөн зөвхөн харийнханд ч биш харин бүх Израилын угсаанд, Абрахамтай хийсэн тэнгэрийн Эцэгийн гэрээнүүдийг мэдүүлэхийн учраас буюу, үүнд хэлсэнчлэн: Чиний үр удмаар дэлхийн бүх улс адислагдах болно.
- 10 Мөн ах нар минь, тэрээр мутраа үндэстнүүдийн нүдэнд харуулахгүй аваас газар дэлхийн бүх улс адислагдаж чадахгүйг та нар мэдээсэй хэмээнэ би.
- 11 Иймийн тул, Их Эзэн Бурхан өөрийн гэрээнүүд болон сайн мэдээг Израилын угсааны тэдэнд авчрахад мутраа бүх үндэстний нүдэнд харуулах болно.
- 12 Иймийн тул, тэрээр тэднийг боолчлолоос гарган дахин авчрах болно, мөн тэд өвлөж ирсэн нутгуудаа нэгдэн цуглуулагдах болно; мөн тэд битүүлэг байдлаас мөн харанхуйгаас гаргагдах болно; мөн тэд Их Эзэн бол тэдний Аврагч мөн тэдний Гэтэлгэгч, Израилын Хүчит Нэгэн гэдгийг мэдэх болно.
- 13 Мөн бүх дэлхийн садар эм болох тэр, агуу хийгээд жигшүүрт сүмийн цус, тэдний өөрсдийнх нь толгой дээр эргэх болно; учир нь тэд өөр хоорондоо дайтах болно, мөн тэдний өөрсдийнх нь гар дахь сэлэм тэдний өөрсдийнх нь толгой дээр буух болно, мөн тэд өөрсдийнхөө цусанд өөрсдөө согтох болно.

And it meaneth that the time cometh that after all the house of Israel have been scattered and confounded, that the Lord God will raise up a mighty nation among the Gentiles, yea, even upon the face of this land; and by them shall our seed be scattered.

And after our seed is scattered the Lord God will proceed to do a marvelous work among the Gentiles, which shall be of great worth unto our seed; wherefore, it is likened unto their being nourished by the Gentiles and being carried in their arms and upon their shoulders.

And it shall also be of worth unto the Gentiles; and not only unto the Gentiles but unto all the house of Israel, unto the making known of the covenants of the Father of heaven unto Abraham, saying: In thy seed shall all the kindreds of the earth be blessed.

And I would, my brethren, that ye should know that all the kindreds of the earth cannot be blessed unless he shall make bare his arm in the eyes of the nations.

Wherefore, the Lord God will proceed to make bare his arm in the eyes of all the nations, in bringing about his covenants and his gospel unto those who are of the house of Israel.

Wherefore, he will bring them again out of captivity, and they shall be gathered together to the lands of their inheritance; and they shall be brought out of obscurity and out of darkness; and they shall know that the Lord is their Savior and their Redeemer, the Mighty One of Israel.

And the blood of that great and abominable church, which is the whore of all the earth, shall turn upon their own heads; for they shall war among themselves, and the sword of their own hands shall fall upon their own heads, and they shall be drunken with their own blood.

- 14 Мөн таны эсрэг байлдах үндэстэн бүр, Ай Израилын угсаа, нэг нь нөгөөгийнхөө эсрэг эргүүлэгдэх болно, мөн тэд Их Эзэний хүмүүсийг урхидахаар ухсан тэр нүхэндээ өөрсдөө унах болно. Мөн Сионы эсрэг тулалдах тэд бүгд устгагдах болно, мөн Их Эзэний зөв замыг гажуудуулсан тэр, агуу садар эм, тийм ээ, тэр агуу хийгээд жигшүүрт сүм газар шурган унаж мөн үүний уналт агуу байх болно.
- 15 Учир нь болгоогтун, Сатан хүмүүний үрсийн зүрхийг давах хүчийг дахин эзэмшихгүй байх тэр цаг удахгүй ирнэ; учир нь бүх бардам болоод ёс бусаар үйлдэгч хэн боловч талбайд үлдсэн сүрэл лугаа адил болох өдөр удахгүй ирнэ; мөн тэд шатаагдах ёстой өдөр ч удахгүй ирнэ хэмээн бошиглогч хэлдэг.
- 16 Өөрөөр хэлбэл хүмүүний бүх үрсийн дээр Бурханы хилэгнэл тэр чигээрээ цутгагдах цаг удахгүй ирнэ; учир нь ёсон бусыг үйлдэгчид зөв шударгыг үйлдэгчдийг устгахыг тэрээр үл тэвчих ажгуу.
- 17 Иймийн тул, дайснуудыг нь бүр түймрээр устгах хэдий ч зөв шударгыг үйлдэгчид хамгаалагдах бөгөөд түүний хилэгнэл тэр чигээрээ тэрчлэн ирэх байлаа ч тэрээр зөв шударгыг үйлдэгчдийг өөрийн хүчээр хамгаалах болно. Иймийн тул, зөв шударгыг үйлдэгчид айхын хэрэггүй; учир нь бошиглогч тийн хэлсэнчлэн, бүр тэрчлэн түймрээр ч гэсэн тэд аврагдах болно.
- 18 Болгоогтун, ах дүү нар минь, би та нарт эдгээр зүйлүүд удахгүй ирэх ёстойг хэлнэ; тийм ээ, бүр цус, мөн түймэр, мөн хөшиглөх утаа ирэх ёстой; мөн энэ нь дэлхийн гадаргууд байх нь зайлшгүй; мөн хэрэв хүмүүн Израилын Ариун Нэгэний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах аваас энэ нь үүнчлэн тэдэнд махан бодийн дагуу ирэх буюу.
- 19 Учрыг болгоогтун, зөв шударгыг үйлдэгчид эрсдэхгүй; өөрөөр хэлбэл Сионы эсрэг тулалдах тэд бүгд тусгаарлагдах цаг гарцаагүй ирэх ёстой.
- 20 Мосегийн ярьсан үгсийн биелэл болгон өөрийн хүмүүст замыг Их Эзэн бэлтгэх нь гарцаагүй, тэрээр хэлрүүн: Бошиглогчийг Их Эзэн та нарын Бурхан та нарт, надад тодруулсны адил, тодруулах ажгуу; түүний та нарт хэлэх юуг боловч бүх зүйлд түүнийг та нар сонсох болно. Мөнхүү улиран тохиох дор тэр бошиглогчийг сонсохгүй хэн боловч бүгд, хүмүүсийн дундаас тусгаарлагдах болно хэмээсэн бөлгөө.

And every nation which shall war against thee, O house of Israel, shall be turned one against another, and they shall fall into the pit which they digged to ensnare the people of the Lord. And all that fight against Zion shall be destroyed, and that great whore, who hath perverted the right ways of the Lord, yea, that great and abominable church, shall tumble to the dust and great shall be the fall of it.

For behold, saith the prophet, the time cometh speedily that Satan shall have no more power over the hearts of the children of men; for the day soon cometh that all the proud and they who do wickedly shall be as stubble; and the day cometh that they must be burned.

For the time soon cometh that the fulness of the wrath of God shall be poured out upon all the children of men; for he will not suffer that the wicked shall destroy the righteous.

Wherefore, he will preserve the righteous by his power, even if it so be that the fulness of his wrath must come, and the righteous be preserved, even unto the destruction of their enemies by fire. Wherefore, the righteous need not fear; for thus saith the prophet, they shall be saved, even if it so be as by fire.

Behold, my brethren, I say unto you, that these things must shortly come; yea, even blood, and fire, and vapor of smoke must come; and it must needs be upon the face of this earth; and it cometh unto men according to the flesh if it so be that they will harden their hearts against the Holy One of Israel.

For behold, the righteous shall not perish; for the time surely must come that all they who fight against Zion shall be cut off.

And the Lord will surely prepare a way for his people, unto the fulfilling of the words of Moses, which he spake, saying: A prophet shall the Lord your God raise up unto you, like unto me; him shall ye hear in all things whatsoever he shall say unto you. And it shall come to pass that all those who will not hear that prophet shall be cut off from among the people.

- 21 Мөн эдүгээ би, Нифай, Мосегийн ярьсан тэр бошиглогч нь Израилын Ариун Нэгэн байсныг та нарт тунхаглана; иймийн тул, тэрбээр шүүлтийг зөв шударгаар гүйцэтгэнэ.
- 22 Мөн зөв шударгыг үйлдэгчид айх хэрэггүй, учир юун хэмээвээс бусниулагдахгүй тэд бол тэд бөлгөө. Гэвч чөтгөрийн хаант улс, хүмүүний үрсийн дунд босгогдох тэр, маханбодид орших тэдний дунд байгуулагдах хаант улс—
- 23 Өөрөөр хэлбэл баяжиж хөлжихөөр баригдсан, мөн маханбодийг давах хүчийг олохоор баригдсан тэд бүгд, мөн дэлхийнхний нүдэнд алдрыг олохоор баригдсан тэд, мөн биеийн шуналыг, мөн дэлхийн зүйлийг, мөн бүх төрлийн алдсыг үйлдэхийг эрэлхийлдэг тэд, тэдгээр бүх сүмүүд; тийм ээ, чухамдаа, чөтгөрийн хаант улсад харьяалагдах тэд бүгд айж, мөн чичирч, мөн салгалах хэрэгтэй тэр цаг удахгүй ирэх болно; тэд бол шороо тоос мэт дорд үзэгдэх ёстой тэд буюу; тэд бол талбайд үлдсэн сүрэл лугаа адил үрэгдэх ёстой тэд болой; мөн энэ нь бошиглогчийн үгсийн дагуу буюу.
- 24 Мөн зөв шударгыг үйлдэгчид пүнзэнд байх тугалууд лугаа адил хөтлөгдөх ёстой, мөн Израилын Ариун Нэгэн хүч, мөн чадал, мөн агуу алдар суугаар эзэмшилдээ хаанчлах ёстой, тэрхүү цаг хурдан ирнэ.
- 25 Мөн тэрээр дэлхийн дөрвөн зүгээс хүүхдүүдээ цуглуулна; мөн тэрээр хонио тоолж, мөн тэд түүнийг мэднэ; мөн нэг сүрэг мөн нэг хоньчин байх болно; мөн тэрээр өөрийн хоньдыг тэжээж, мөн түүнд бэлчээрийг тэд олох болно.
- 26 Мөн түүний хүмүүсийн зөв шударгын улмаас, Сатан хүчгүй байна; иймийн тул, тэр олон жилийн хугацаанд чөлөөлөгдөж чадахгүй; учир нь тэр хүмүүсийн зүрхийг давах хүчгүй байна, учир нь тэд зөв шударгад оршиж, мөн Израилын Ариун Нэгэн хаанчлах бөлгөө.
- 27 Мөн эдүгээ болгоогтун, би, Нифай, эдгээр бүх зүйл маханбодийн дагуу ирэх ёстойг та нарт хэлж байна.
- 28 Гэвч болгоогтун, бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүс хэрэв энэ нь түүнчлэн байж тэд наманчлах аваас Израилын Ариун Нэгэнд аюулгүйгээр орших болно.

And now I, Nephi, declare unto you, that this prophet of whom Moses spake was the Holy One of Israel; wherefore, he shall execute judgment in righteousness.

And the righteous need not fear, for they are those who shall not be confounded. But it is the kingdom of the devil, which shall be built up among the children of men, which kingdom is established among them which are in the flesh—

For the time speedily shall come that all churches which are built up to get gain, and all those who are built up to get power over the flesh, and those who are built up to become popular in the eyes of the world, and those who seek the lusts of the flesh and the things of the world, and to do all manner of iniquity; yea, in fine, all those who belong to the kingdom of the devil are they who need fear, and tremble, and quake; they are those who must be brought low in the dust; they are those who must be consumed as stubble; and this is according to the words of the prophet.

And the time cometh speedily that the righteous must be led up as calves of the stall, and the Holy One of Israel must reign in dominion, and might, and power, and great glory.

And he gathereth his children from the four quarters of the earth; and he numbereth his sheep, and they know him; and there shall be one fold and one shepherd; and he shall feed his sheep, and in him they shall find pasture.

And because of the righteousness of his people, Satan has no power; wherefore, he cannot be loosed for the space of many years; for he hath no power over the hearts of the people, for they dwell in righteousness, and the Holy One of Israel reigneth.

And now behold, I, Nephi, say unto you that all these things must come according to the flesh.

But, behold, all nations, kindreds, tongues, and people shall dwell safely in the Holy One of Israel if it so be that they will repent.

29 Мөн эдүгээ би, Нифай, төгсгөл болгоё; учир нь би эдгээр зүйлүүдийн талаар одоохондоо цааш ярьж эс зүрхлэх авай.

30 Иймийн тул, ах нар минь, би та нарыг гуулин ялтсууд дээр бичигдсэн зүйлүүд үнэн гэдгийг анхаарч үзэхийг хүсэж байна; мөн тэдгээр нь Бурханы зарлигуудад хүмүүн дуулгавартай байх ёстойг гэрчилдэг билээ.

31 Иймийн тул, зөвхөн миний эцэг бид хоёр л гэрчилж, мөн түүнчлэн тэдгээрийг заасан юм гэж та нар бодох хэрэггүй. Иймийн тул, хэрэв та нар зарлигуудад дуулгавартай байж, мөн эцсийг хүртэл тэвчвээс, та нар эцсийн өдөр аврагдах болно. Мөн энэ нь ийм болой. Амен.

And now I, Nephi, make an end; for I durst not speak further as yet concerning these things.

Wherefore, my brethren, I would that ye should consider that the things which have been written upon the plates of brass are true; and they testify that a man must be obedient to the commandments of God.

Wherefore, ye need not suppose that I and my father are the only ones that have testified, and also taught them. Wherefore, if ye shall be obedient to the commandments, and endure to the end, ye shall be saved at the last day. And thus it is. Amen.

# НИФАЙН ХОЁР ДАХЬ НОМ

*Лихайн үхлийн тухай цэдэг оршвой. Нифайн ах нар түүнийг эсэргүүцэв. Их Эзэн Нифайд аглаг буйд тийш одохыг сануулан зөвлөв. Түүний аглаг буйд дахь аян мөн цаашдын үргэлжлэл оршвой.*

## 2 Нифай 1

- 1 МөнХҮҮ эдүгээ улиран тохиох дор би, Нифай, ах нартаа сургамжлан байснаа төгсгөл болгосны дараа, бидний эцэг, Лихай, түүнчлэн тэдэнд олон зүйлийг ярьж, мөн тэднийг Иерусалим нутгаас авчирснаараа Их Эзэн тэдний төлөө ямар агуу зүйлийг үйлдсэнийг давтан өгүүлэв.
- 2 Мөн тэрээр тэдэнд хандан тэдний усан дээрх эсэргүүцлийн, мөн далайд үйхээс тэдний амийг хэлтрүүлсэн Бурханы нигүүлслийн талаар ярив.
- 3 Мөн түүнчлэн тэрээр тэдэнд хандан тэдний эзэмшсэн тэр амлалтын нутгийн талаар—биднийг Иерусалим нутгаас зайлан гарахыг бидэнд сэргийлэн сануулснаараа Их Эзэн ямар нигүүлсэнгүй байсныг ярьсан билээ.
- 4 Тэрээр хэлэв, учир нь болгоогтун, Иерусалим устгагдсаныг мэдүүлэх нэгэн үзэгдлийг би харав; мөн бид Иерусалимд үлдсэн аваас бид ч түүнчлэн эрсдэх байсан биз ээ.
- 5 Тэрээр хэлэв, гэвч, бид зовж зүдэрсэн ч, бид амлалтын нутгийг эзэмшсэн, бүхий л нутгуудаас сонгомол тэр нутгийг бөлгөө; миний үр удамд өвлүүлэхээр Их Эзэн Бурхан надтай гэрээ хийсэн тэр нутгийг бөлгөө. Тийм ээ, Их Эзэн энэ нутгийг надад бас миний хүүхдүүдэд, мөн түүнчлэн Их Эзэний мутраар бусад орнуудаас удирдагдах тэд бүгдэд үүрд гэрээлэн өгсөн билээ.
- 6 Иймийн тул, би, Лихай, надад орших Сүнсний нөлөөний дагуу, Их Эзэний мутраар тэд авчрагдахаас бусдаар хэн ч энэ нутагт ирэхгүйг бошиглон хэлж байна.

# The Second Book of Nephi

*An account of the death of Lehi. Nephi's brethren rebel against him. The Lord warns Nephi to depart into the wilderness. His journeyings in the wilderness, and so forth.*

## 2 Nephi 1

And now it came to pass that after I, Nephi, had made an end of teaching my brethren, our father, Lehi, also spake many things unto them, and rehearsed unto them, how great things the Lord had done for them in bringing them out of the land of Jerusalem.

And he spake unto them concerning their rebellions upon the waters, and the mercies of God in sparing their lives, that they were not swallowed up in the sea.

And he also spake unto them concerning the land of promise, which they had obtained—how merciful the Lord had been in warning us that we should flee out of the land of Jerusalem.

For, behold, said he, I have seen a vision, in which I know that Jerusalem is destroyed; and had we remained in Jerusalem we should also have perished.

But, said he, notwithstanding our afflictions, we have obtained a land of promise, a land which is choice above all other lands; a land which the Lord God hath covenanted with me should be a land for the inheritance of my seed. Yea, the Lord hath covenanted this land unto me, and to my children forever, and also all those who should be led out of other countries by the hand of the Lord.

Wherefore, I, Lehi, prophesy according to the workings of the Spirit which is in me, that there shall none come into this land save they shall be brought by the hand of the Lord.



7 Иймийн тул, түүний авчрах түүнд энэ нутаг ариулан адислагдсан буюу. Мөн хэрэв энэ нь үүнчлэн байж тэд түүний өгсөн зарлигуудын дагуу түүнд үйлчлэх аваас, энэ нь тэдэнд эрх чөлөөний нутаг байх болно; иймийн тул, тэд хэзээ ч боолчлол дор авчрагдахгүй; хэрэв үүнчлэн тохиовол энэ нь алдсуудын учир болой; учир нь хэрэв алдас ихээр оршвоос уг нутаг тэдний хувьд зүхэгдэнэ, гэвч зөв шударгыг үйлдэгчдэд энэ нь үүрд адислагдах болно.

8 Мөн болгоогтун, энэ нутаг бусад зарим үндэстнүүдэд харахан мэдэгдэхгүйгээр хадгалагдах нь мэргэн ухаан болой; учир нь болгоогтун, олон үндэстэн уг нутгийг хөндлөн гулд туучсан аваас, өвлөгдөх газаргүй байх сан билээ.

9 Иймийн тул, Их Эзэн, Бурхан Иерусалим нутгаас авчрах тэд түүний зарлигуудыг дагахын хэрээр, тэд энэ нутгийн гадаргуу дээр дэгжих болно; мөн тэд энэ нутгийг өөрсдөдөө эзэмшиж болохын тулд тэд бусад бүх үндэстнээс хамгаалах болно гэдэг амлалтыг Лихай, би олж авсан билээ. Мөн хэрэв тэд түүний зарлигуудыг дагаваас тэд энэ нутгийн гадаргуу дээр адислагдаж, мөн тэднийг гоочлох нэгээхэн ч, бас тэдний өвлөх нутгийг булаан авах хэн ч байхгүй байх болно; мөн тэд үүрд аюулгүй орших болно.

10 Гэвч болгоогтун, газар дэлхийн мөн бүх хүмүүний бүтээгдсэн мэдлэгийг эзэмшиж; дэлхий бүтээгдсэнээс хойших Их Эзэний агуу хийгээд гайхамшигт ажлуудыг мэдэж; итгэлээр бүх зүйлийг үйлдэх хүч тэдэнд өгөгдсөи юм; мөн бүх зарлигууд эхлэлээс өгөгдөх болно, мөн түүний хэмжээлшгүй сайн чанараар энэ эрхэм сайхан амлалтын нутагт авчрагдах агуу адислалуудыг Их Эзэний мутраас хүлээн авсныхаа дараа тэд итгэлгүйдээ бууран доройтох цаг нь ирэхэд—болгоогтун, би хэлнэ, хэрэв тэд үнэн Мессиа, тэдний Гэтэлгэгч, мөн тэдний Бурхан, Израилын Ариун Нэгэнийг эсэргүүцэх өдөр ирэх аваас, болгоогтун, түүний шударга шүүлтүүд тэдний дээр ирэх ажгуу.

11 Тийм ээ, тэрээр тэдний дээр бусад үндэстнүүд болох тэднийг авчрах болно, мөн тэрээр тэдэнд хүчийг өгч, мөн тэрээр тэднээс эзэмшил газруудыг нь салган авч, мөн тэрээр тэднийг тарагдсан бас бут цохигдсон байлгах болно.

Wherefore, this land is consecrated unto him whom he shall bring. And if it so be that they shall serve him according to the commandments which he hath given, it shall be a land of liberty unto them; wherefore, they shall never be brought down into captivity; if so, it shall be because of iniquity; for if iniquity shall abound cursed shall be the land for their sakes, but unto the righteous it shall be blessed forever.

And behold, it is wisdom that this land should be kept as yet from the knowledge of other nations; for behold, many nations would overrun the land, that there would be no place for an inheritance.

Wherefore, I, Lehi, have obtained a promise, that inasmuch as those whom the Lord God shall bring out of the land of Jerusalem shall keep his commandments, they shall prosper upon the face of this land; and they shall be kept from all other nations, that they may possess this land unto themselves. And if it so be that they shall keep his commandments they shall be blessed upon the face of this land, and there shall be none to molest them, nor to take away the land of their inheritance; and they shall dwell safely forever.

But behold, when the time cometh that they shall dwindle in unbelief, after they have received so great blessings from the hand of the Lord—having a knowledge of the creation of the earth, and all men, knowing the great and marvelous works of the Lord from the creation of the world; having power given them to do all things by faith; having all the commandments from the beginning, and having been brought by his infinite goodness into this precious land of promise—behold, I say, if the day shall come that they will reject the Holy One of Israel, the true Messiah, their Redeemer and their God, behold, the judgments of him that is just shall rest upon them.

Yea, he will bring other nations unto them, and he will give unto them power, and he will take away from them the lands of their possessions, and he will cause them to be scattered and smitten.

- 12 Тийм ээ, нэг үе нөгөөгөө халахад цус урсан, мөн агуу цээрлэлүүд тэдний дунд байх болно; иймийн тул, хөвгүүд минь, та нарыг санаасай хэмээнэ би; тийм ээ, та нарыг миний үгсийг анхаараасай хэмээнэ би.
- 13 Ай та нар сэрээсэй; гүн нойрноос сэрээсэй; тийм ээ, бүр тамын нойрноос, тэгээд та нар хүлэгдсэн тэр аймшигт гинжээ сэгсрэн зайлуулаасай хэмээнэ, зовлон гамшгийн мөнхийн ангалд тэднийг доош олзлон хүргэхийн тулд хүмүүний үрсийг хүлэх тэр гинжийг буюу.
- 14 Сэрэгтүн! Тэгээд газар шорооноос бос, мөн үе мөчүүдийг нь, тэндээс нэгээхэн ч аянчин буцаж ирж чадахгүй тэрхүү хүйтэн бас чимээгүй булшинд та нарыг удахгүй хэвтүүлэх ёстой, салгалан чичрэх эцгийн үгсийг сонс; дахиад хэдхэн өдөр, тэгээд би энэ дэлхийн жамаар явна.
- 15 Гэвч болгоогтун, Их Эзэн бодгалийг минь тамаас гэтэлгэсэн; би түүний алдар сууг болгоож, мөн би түүний хайрын мутраар мөнхөд хүрээлүүлсэн буюу.
- 16 Мөн та нар Их Эзэний дүрэм болон тогтоолуудыг мөрдөхийг санаасай хэмээн хүснэм би; болгоогтун, энэ нь эхнээсээ бодгалийн минь зовнил байсан бөлгөө.
- 17 Миний зүрх сэтгэл цагаас цагт харамсалдаа хүндрэн байв, та нарын зүрх сэтгэл хатуугийн учир Их Эзэн та нарын Бурхан, хилэгнэлээ тэр чигээр нь та нарын дээр гарган та нарыг үүрд зайлуулж бас устгах буйза;
- 18 Эсвээс, олон үеийн турш зүхэл та нар дээр ирэх болно; мөн та нар илдээр, мөн өлсгөлөн, бас үзэн ядалтаар дайлагдаж мөн чөтгөрийн таалал хийгээд боолчлолын дагуу удирдагдах бий хэмээн эмээхийн учир бөлгөө.
- 19 Ай хөвгүүд минь, эдгээр зүйлүүд та нарын дээр ирэхгүй байж болно, харин та нар Их Эзэний сонгомол мөн таалалт хүмүүс байгаасай. Гэвч болгоогтун, түүний тааллаар бүтэх болтугай; учир нь түүний замууд үүрд зөв шударга болой.

Yea, as one generation passeth to another there shall be bloodsheds, and great visitations among them; wherefore, my sons, I would that ye would remember; yea, I would that ye would hearken unto my words.

O that ye would awake; awake from a deep sleep, yea, even from the sleep of hell, and shake off the awful chains by which ye are bound, which are the chains which bind the children of men, that they are carried away captive down to the eternal gulf of misery and woe.

Awake! and arise from the dust, and hear the words of a trembling parent, whose limbs ye must soon lay down in the cold and silent grave, from whence no traveler can return; a few more days and I go the way of all the earth.

But behold, the Lord hath redeemed my soul from hell; I have beheld his glory, and I am encircled about eternally in the arms of his love.

And I desire that ye should remember to observe the statutes and the judgments of the Lord; behold, this hath been the anxiety of my soul from the beginning.

My heart hath been weighed down with sorrow from time to time, for I have feared, lest for the hardness of your hearts the Lord your God should come out in the fulness of his wrath upon you, that ye be cut off and destroyed forever;

Or, that a cursing should come upon you for the space of many generations; and ye are visited by sword, and by famine, and are hated, and are led according to the will and captivity of the devil.

O my sons, that these things might not come upon you, but that ye might be a choice and a favored people of the Lord. But behold, his will be done; for his ways are righteousness forever.

- 20 Мөн тэрээр хэлсэн байдаг: та нар миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно; харин та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар миний дэргэдээс зайлуулагдах болно.
- 21 Мөн эдүгээ бодгаль минь та нарт баясаж болохын тулд, мөн миний зүрх та нарын учир баяртайгаар энэ дэлхийг орхиж болохын тулд, уйтгар гуниг болон харамслыг тээн доош булшинд аваачигдахгүй байж болохын тулд, газар шорооноос бос, хөвгүүд минь, мөн эр хүн шиг бай, бүх зүйлүүдэд нэгдэн хамтарч бас хатуу шийдэмгий нэг бодол мөн нэг сэтгэлтэй бай, та нар боолчлолд орохгүй байж болохын тулд буюу.
- 22 Та нар зовлонт зүхлээр зүхэгдэхгүйн тулд; мөн түүнчлэн, та нар өөрсдийн дээр устгалд, тийм ээ, сүнс болон биеийн аль алиных нь мөнхийн устгалд хүргэх, шударга Бурханы харамсал дургүйцлийг хүртэхгүй байж болохын тулд буюу.
- 23 Сэрцгээ, хөвгүүд минь; зөв шударгын хуягийг өмсөцгөө. Та нарыг хүлсэн тэр гинжийг сэгсрэн хая, тэгээд түнэр харанхуйгаас гарч ир, мөн газар шорооноос бос.
- 24 Мөн бид Иерусалимыг орхисон тэр цагаас, зарлигуудыг дагасан, мөн биднийг амлалтын нутагт авчрахад Бурханы мутарт зэмсэг болж байсан, түүний үзсэн нь дуурсгалт болох тэр дүүгийнхээ өөдөөс дахин бүү эсэргүүц; учир нь тэрбээр байгаагүй сэн бол бид аглаг буйдад өлсөж эрсдэх байсан биз ээ; гэсэн хэдий ч та нар түүний амийг авахаар эрэлхийлсэн; тийм ээ, мөн тэрээр та нарын улмаас их шаналлыг амссан билээ.
- 25 Мөн тэрээр дахин зовох болов уу хэмээн би үлэмж айж бас дагжих нь та нарын улмаас бөлгөө, учир нь болгоогтун, тэрээр та нарыг давах хүч чадал болон эрх мэдлийг эрэлхийллээ гэж та нар түүнийг буруутгасан билээ; гэвч тэрээр та нарыг давах хүч чадал мөн эрх мэдлийг ч эрэлхийлээгүй, харин тэрээр Бурханы алдар суут, мөн та нарын өөрсдийн тань мөнхийн зол жаргалыг эрэлхийлснийг би мэднэ.

And he hath said that: Inasmuch as ye shall keep my commandments ye shall prosper in the land; but inasmuch as ye will not keep my commandments ye shall be cut off from my presence.

And now that my soul might have joy in you, and that my heart might leave this world with gladness because of you, that I might not be brought down with grief and sorrow to the grave, arise from the dust, my sons, and be men, and be determined in one mind and in one heart, united in all things, that ye may not come down into captivity;

That ye may not be cursed with a sore cursing; and also, that ye may not incur the displeasure of a just God upon you, unto the destruction, yea, the eternal destruction of both soul and body.

Awake, my sons; put on the armor of righteousness. Shake off the chains with which ye are bound, and come forth out of obscurity, and arise from the dust.

Rebel no more against your brother, whose views have been glorious, and who hath kept the commandments from the time that we left Jerusalem; and who hath been an instrument in the hands of God, in bringing us forth into the land of promise; for were it not for him, we must have perished with hunger in the wilderness; nevertheless, ye sought to take away his life; yea, and he hath suffered much sorrow because of you.

And I exceedingly fear and tremble because of you, lest he shall suffer again; for behold, ye have accused him that he sought power and authority over you; but I know that he hath not sought for power nor authority over you, but he hath sought the glory of God, and your own eternal welfare.

26 Мөн тэрээр та нарт илэн далангүй байсан учраас та нар бувтналдсан. Та нар тэрээр хурц ширүүнийг хэрэглэсэн гэдэг; та нар түүнийг өөрсдөд тань ууртай хандсан гэдэг; гэвч болгоогтун, түүний хурц ширүүн нь түүнд байсан Бурханы үгний хүчний хурц ширүүн байсан болой; мөн та нарын уур гэх тэр нь, тэрээр тэвчиж үл чадан, та нарын алдсуудын талаар шударгаар нотолсон, Бурханд орших үнэний дагуух үнэн билээ.

27 Мөн Бурханы хүч түүнтэй хамт байх ёстой нь зайлшгүй, бүр түүнийг тушаахад та нар дагах ёстой болтол буюу. Гэвч болгоогтун, энэ бол тэр биш, харин энэ бол түүнд оршсон, хамхиж чадахгүй болтол нь түүний амыг нээж яриулах Их Эзэний Сүнс байсан билээ.

28 Мөн эдүгээ Лемен, хөвгүүн минь, мөн түүнчлэн Лемүел мөн Сам, мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүд болох хөвгүүд минь, болгоогтун, хэрэв та нар Нифайн хэлснийг сонсох аваас та нар эрсдэхгүй болой. Мөн хэрэв та нар түүнийг анхааран сонсвоос би та нарт адислалыг үлдээнэ, тийм ээ, бүр өөрийн эхний адислалыг буюу.

29 Гэвч хэрэв та нар түүнийг анхааран сонсохгүй бол би өөрийн эхний адислалыг зайлуулан авна, тийм ээ, бүр өөрийн адислалыг, тэгээд энэ нь түүний дээр орших болно.

30 Мөн эдүгээ, Зорам, би чамд хэлнэ; Болгоогтун, та бол Лебений зарц; гэсэн хэдий ч, чи Иерусалим нутгаас авчрагдсан, мөн чи бол миний хүү Нифайн үүрдийн үнэнч нөхөр гэдгийг би мэднэ.

31 Иймийн тул, чи итгэл хүлээснээс үр удам чинь түүнийхтэй хамт энэ нутгийн гадаргуу дээр удаан хугацаанд дэгжин оршихоор тэд адислагдах болно; мөн тэдний дундах алдсаас өөр юу ч, тэднийг энэ нутгийн гадаргуу дээр үүрд дэвжин хөгжихөд хор хөнөөл үзүүлж мөн саад болж чадахгүй.

32 Иймийн тул, хэрэв та нар Их Эзэний зарлигуудыг дагах аваас, миний хүүгийн үр удамтай хамт чиний үр удмын аюулгүй байдлын тулд энэ нутгийг Их Эзэн ариулан адислах болой.

And ye have murmured because he hath been plain unto you. Ye say that he hath used sharpness; ye say that he hath been angry with you; but behold, his sharpness was the sharpness of the power of the word of God, which was in him; and that which ye call anger was the truth, according to that which is in God, which he could not restrain, manifesting boldly concerning your iniquities.

And it must needs be that the power of God must be with him, even unto his commanding you that ye must obey. But behold, it was not he, but it was the Spirit of the Lord which was in him, which opened his mouth to utterance that he could not shut it.

And now my son, Laman, and also Lemuel and Sam, and also my sons who are the sons of Ishmael, behold, if ye will hearken unto the voice of Nephi ye shall not perish. And if ye will hearken unto him I leave unto you a blessing, yea, even my first blessing.

But if ye will not hearken unto him I take away my first blessing, yea, even my blessing, and it shall rest upon him.

And now, Zoram, I speak unto you: Behold, thou art the servant of Laban; nevertheless, thou hast been brought out of the land of Jerusalem, and I know that thou art a true friend unto my son, Nephi, forever.

Wherefore, because thou hast been faithful thy seed shall be blessed with his seed, that they dwell in prosperity long upon the face of this land; and nothing, save it shall be iniquity among them, shall harm or disturb their prosperity upon the face of this land forever.

Wherefore, if ye shall keep the commandments of the Lord, the Lord hath consecrated this land for the security of thy seed with the seed of my son.

## 2 Нифай 2

- 1 Мөн эдүгээ, Иаков, би чамд ярья: Чи бол аглаг буйда дахь миний зовлонг өдрүүдэд төрсөн ууган хүү минь билээ. Мөн болгоогтун, чи хүүхэд ахуй үедээ ах нарынхаа балмадын учир их харамсал мөн зовлон үзсэн билээ.
- 2 Гэсэн хэдий ч, Иаков, аглаг буйдад төрсөн ууган хүү минь, чи Бурханы агуу ихийг мэдэх бөлгөө; мөн тэрээр зовлонгуудыг чинь чиний өсөлт хөгжлийн тул ариулан адислах болно.
- 3 Иймийн тул, бодгаль чинь адислагдсан болой, мөн чи ах Нифайнхаа хамт аюулгүй орших болно; мөн чиний өдрүүд өөрийн Бурханд үйлчлэхэд зориулагдсан байх болно. Иймийн тул, Гэтэлгэгчийнхээ зөв шударгын учир чибээр гэтэлгэгдсэнийг би мэднэ; учир нь хүн төрөлхтөнд авралыг авчрахаар тэрээр цаг хугацааны бүрэн байдалд ирэхийг нь чи үзсэн билээ.
- 4 Мөн түүний алдар сууг залуу насандаа чи үзсэн билээ; иймийн тул, тэрээр бүр өөрийн биеэр тохиноулах тэдний нэгэн адил адислагдсан чи; учир нь Сүнс өчигдөр, өнөөдөр бас үүрд нэгэн адил бөлгөө. Мөн хүмүүний уналтаас зам нь бэлтгэгдсэн, бас аврал бол өглөг буюу.
- 5 Мөн хүмүүн нь тэд сайныг муугаас ялгаж мэдэхээр хангалттай зааварлагдсан буюу. Мөн хууль нь хүмүүнд өгөгдсөн болой. Мөн хуулийн дагуу зөвтгөгдөх маханбодь гэж үгүй; өөрөөр хэлбэл, хуулиар хүмүүн тусгаарлагдсан байна. Тийм ээ, зуурдын хуулиар тэд тусгаарлагдсан; мөн түүнчлэн, сүнслэг хуулиар тэд сайнаас хагацаж эрсдэн, мөн үүрд золгүй болох бөлгөө.
- 6 Иймийн тул Ариун Мессиа, түүнд мөн түүгээр гэтэлгэл ирнэ; учир нь тэрээр ач ивээл хийгээд үнэнээр дүүрэн буюу.
- 7 Болгоогтун, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй хэний ч төлөө хуулийн шаардлагуудыг хангаж, тэрээр нүглийн золиослол болгон өөрийгөө өргөх ажгуу; мөн хуулийн бүх шаардлагууд өөр хэний ч төлөө хангагдаж чадахгүй.

## 2 Nephi 2

And now, Jacob, I speak unto you: Thou art my first-born in the days of my tribulation in the wilderness. And behold, in thy childhood thou hast suffered afflictions and much sorrow, because of the rudeness of thy brethren.

Nevertheless, Jacob, my firstborn in the wilderness, thou knowest the greatness of God; and he shall consecrate thine afflictions for thy gain.

Wherefore, thy soul shall be blessed, and thou shalt dwell safely with thy brother, Nephi; and thy days shall be spent in the service of thy God. Wherefore, I know that thou art redeemed, because of the righteousness of thy Redeemer; for thou hast beheld that in the fulness of time he cometh to bring salvation unto men.

And thou hast beheld in thy youth his glory; wherefore, thou art blessed even as they unto whom he shall minister in the flesh; for the Spirit is the same, yesterday, today, and forever. And the way is prepared from the fall of man, and salvation is free.

And men are instructed sufficiently that they know good from evil. And the law is given unto men. And by the law no flesh is justified; or, by the law men are cut off. Yea, by the temporal law they were cut off; and also, by the spiritual law they perish from that which is good, and become miserable forever.

Wherefore, redemption cometh in and through the Holy Messiah; for he is full of grace and truth.

Behold, he offereth himself a sacrifice for sin, to answer the ends of the law, unto all those who have a broken heart and a contrite spirit; and unto none else can the ends of the law be answered.

- 8 Иймийн тул, хамгийн эхэнд байж амилснаараа тэрээр, үхэгсдийн амилуулалтыг гүйцэлдүүлж болохын тулд, өөрийн амийг маханбодийн дагуу өгч, Сүнсний хүчээр үүнийгээ дахин авах Ариун Мессиагийн сайн үйл мөн нигүүлсэл, мөн ач ивээлээр биш болбоос нэг ч бие Бурханы дэргэд оршиж чадахгүйг тэд мэдэж болохын тулд эдгээр зүйлийг газар дэлхийн оршин суугчдад мэдүүлэх нь хичнээн их чухал билээ.
- 9 Иймийн тул, тэрээр бүх хүмүүний үрсийг өмгөөлөхийн учир, тэрээр Бурханы хувьд эхний үр жимс бөлгөө; мөн түүнд итгэх тэд аврагдах болно.
- 10 Мөн бүгдэд зориулагдсан өмгөөллийн учир, бүх хүмүүн Бурханд ирнэ; иймийн тул, түүнд байх үнэн болон ариун байдлын дагуу түүгээр шүүгдэхийн тулд тэд түүний дэргэд зогсох болно. Иймийн тул, цагаатгалын зорилгыг гүйцэлдүүлэхээр, тогтоогдсон шийтгэлийг оногдуулах, тогтоогдсон аз жаргалын эсрэг байх тэрхүү тогтоогдсон шийтгэл, Ариун Нэгэний өгсөн хуулийн тэр шаардлагууд—
- 11 Учир юун хэмээвээс бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй. Хэрэв тийм бус аваас, аглаг буйдад төрсөн ууган хүү минь, зөв шударга нь бас ёсон бус ч, ариун нандин хийгээд зовлон шаналал ч, сайн бас муу ч тохиохгүй болой. Иймийн тул, бүх зүйл нэгэнд нийлэн байх нь зайлшгүй; иймийн тул, хэрэв энэ нь нэгэн биед оршвоос энэ нь үхдэл лугаа адил байх ёстой, үхэл үгүй бас амьдрал ч үгүй, ялзрал үгүй бас муудашгүй байдал ч үгүй, зовлонгүй бас жаргал ч үгүй, мөн хатуу сэтгэл үгүй бас саруул ухаан ч гэж байх нь үгүйн учир буюу.
- 12 Иймийн тул, хоосон зүйлийн тулд зайлшгүй бүтээгдэх ёстой байсан; иймийн тул, үүний бүтээлтийн зорилгод утгагүй байх байсан. Иймийн тул, энэ зүйл нь Бурханы мэргэн ухаан мөн түүний мөнхийн зорилгууд, мөн түүнчлэн Бурханы хүч, мөн нигүүлсэл, мөн шударга ёсыг зайлшгүй устгах бөлгөө.

Wherefore, how great the importance to make these things known unto the inhabitants of the earth, that they may know that there is no flesh that can dwell in the presence of God, save it be through the merits, and mercy, and grace of the Holy Messiah, who layeth down his life according to the flesh, and taketh it again by the power of the Spirit, that he may bring to pass the resurrection of the dead, being the first that should rise.

Wherefore, he is the firstfruits unto God, inasmuch as he shall make intercession for all the children of men; and they that believe in him shall be saved.

And because of the intercession for all, all men come unto God; wherefore, they stand in the presence of him, to be judged of him according to the truth and holiness which is in him. Wherefore, the ends of the law which the Holy One hath given, unto the inflicting of the punishment which is affixed, which punishment that is affixed is in opposition to that of the happiness which is affixed, to answer the ends of the atonement—

For it must needs be, that there is an opposition in all things. If not so, my firstborn in the wilderness, righteousness could not be brought to pass, neither wickedness, neither holiness nor misery, neither good nor bad. Wherefore, all things must needs be a compound in one; wherefore, if it should be one body it must needs remain as dead, having no life neither death, nor corruption nor incorruption, happiness nor misery, neither sense nor insensibility.

Wherefore, it must needs have been created for a thing of naught; wherefore there would have been no purpose in the end of its creation. Wherefore, this thing must needs destroy the wisdom of God and his eternal purposes, and also the power, and the mercy, and the justice of God.

13 Мөн хэрэв та нар хууль үгүй хэмээвээс, та нар түүнчлэн нүгэл гэж үгүй гэх болно. Хэрэв та нар нүгэл үгүй хэмээн хэлэх аваас, та нар түүнчлэн зөв шударга гэж үгүй гэх болно. Мөн хэрэв зөв шударга гэж үгүй аваас аз жаргал ч үгүй байх буюу. Мөн хэрэв зөв шударга бас аз жаргал ч үгүй бол шийтгэл бас зовлон ч үгүй бөлгөө. Мөн хэрэв эдгээр зүйлүүд үгүй бөгөөс Бурхан гэж үгүй. Мөн хэрэв Бурхан үгүй бөгөөс бид ч, мөн дэлхий ч үгүй байх байсан; учир нь юмсын бүтээл байхгүй, үйлдэх нь ч үйлдүүлэх нь ч бас үгүй бөлгөө; иймийн тул, бүх зүйл алга болох ёстой буюу.

14 Мөн эдүгээ, хөвгүүд минь, би та нарт хандан та нарын эрдэм мөн тусын тулд эдгээр зүйлийг ярья; өөрөөр хэлбэл Бурхан буй, мөн тэрээр бүх зүйлийг, тэнгэр мөн газрыг аль алиныг нь, мөн тэнд орших бүх зүйлийг, үйлдэх зүйлүүд болон үйлдүүлэх зүйлийг аль алиныг нь бүтээсэн болой.

15 Мөн өөрийн мөнхийн зорилгуудыг хүмүүний зорилтонд гүйцэлдүүлэхэд, тэрээр бидний анхны эх эцгийг мөн газар дээрх араатан амьтад бас агаар дахь жигүүртнийг, мөн эцэст нь хэлэхэд, бүтээгдсэн тэдгээр бүх зүйлийг бүтээсний дараа эсрэг талууд нь зайлшгүй байх ёстой болжээ; бүр хориглогдсон жимс нь амьдралын модны эсрэг зүйл юм; нэг нь амттай мөн нөгөө нь гашуун бөлгөө.

16 Иймийн тул, Их Эзэн Бурхан хүнд өөрөө үйлдэх боломжийг өгчээ. Иймийн тул, тэрээр нэгээр эсвэл нөгөөд татагдсан байхаас бусдаар хүн өөрөө үйлдэж чадахгүй байх сан билээ.

17 Мөн би, Лихай, уншсан зүйлүүдийнхээ дагуу, Бурханы нэгэн тэнгэр элч, бичигдсэний дагуу тэнгэрээс унасан хэмээн бодох ёстой болов; иймийн тул, тэрээр Бурханы өмнө хорт мууг эрэлхийлсний учир чөтгөр болсон бөлгөө.

18 Мөн тэрээр тэнгэрээс унасан, мөн үүрд зовлонг болсны учир, тэрээр түүнчлэн бүх хүн төрөлхтний зовлонг эрэлхийлсэн болой. Иймийн тул, тэрээр Евад хэлж, тийм ээ, чөтгөр болох, худал бүгдийн эцэг болох тэр, бүр хөгшин могой, иймийн тул тэрээр хэлж: хориглогдсон жимснээс хүрт, мөн та нар үхэхгүй, харин та нар Бурханы адил сайн болон мууг мэдэх болно хэмээв.

And if ye shall say there is no law, ye shall also say there is no sin. If ye shall say there is no sin, ye shall also say there is no righteousness. And if there be no righteousness there be no happiness. And if there be no righteousness nor happiness there be no punishment nor misery. And if these things are not there is no God. And if there is no God we are not, neither the earth; for there could have been no creation of things, neither to act nor to be acted upon; wherefore, all things must have vanished away.

And now, my sons, I speak unto you these things for your profit and learning; for there is a God, and he hath created all things, both the heavens and the earth, and all things that in them are, both things to act and things to be acted upon.

And to bring about his eternal purposes in the end of man, after he had created our first parents, and the beasts of the field and the fowls of the air, and in fine, all things which are created, it must needs be that there was an opposition; even the forbidden fruit in opposition to the tree of life; the one being sweet and the other bitter.

Wherefore, the Lord God gave unto man that he should act for himself. Wherefore, man could not act for himself save it should be that he was enticed by the one or the other.

And I, Lehi, according to the things which I have read, must needs suppose that an angel of God, according to that which is written, had fallen from heaven; wherefore, he became a devil, having sought that which was evil before God.

And because he had fallen from heaven, and had become miserable forever, he sought also the misery of all mankind. Wherefore, he said unto Eve, yea, even that old serpent, who is the devil, who is the father of all lies, wherefore he said: Partake of the forbidden fruit, and ye shall not die, but ye shall be as God, knowing good and evil.

19 Мөн Адам Ева хоёр хориглогдсон жимснээс хүртсэний дараа тэд Еденийн цэцэрлэгээс газар боловсруулахаар зайлуулагдсан билээ.

20 Мөн тэд хүүхдүүд төрүүлэв; тийм ээ, бүр бүх дэлхийн гэр бүлийг.

21 Мөн маханбодид байхдаа тэд наманчилж болохын тулд, хүмүүний үрсийн өдрүүд Бурханы тааллын дагуу уртасгагджээ; иймийн тул, Их Эзэн Бурхан хүмүүний үрсэд өгсөн тэрхүү зарлигуудын дагуу тэдний байдал сорилтын байдал болж, мөн тэдний хугацаа уртассан бөлгөө. Өөрөөр хэлбэл бүх хүмүүн наманчлах ёстой гэсэн зарлиг тэрээр өгчээ; учир нь тэдгээр нь өөрсдийн эцэг эхийн алдсын учир төөрөлдсөнийг тэрээр бүх хүмүүнд үзүүлсэн юм.

22 Мөн эдүгээ, болгоогтун, хэрэв Адам зөрчил үйлдээгүй аваас тэрээр унахгүй, харин тэр Еденийн цэцэрлэгт үлдэх байсан билээ. Мөн бүтээгдсэн бүх зүйл тэд бүтээгдсэнийхээ дараа байсан тэр байдлаараа нэгэн адил үлдэх ёстой байсан бөлгөө; мөн тэд үүрд, мөн төгсгөлгүйгээр үлдэх ёстой байсан бөлгөө.

23 Мөн тэд хүүхдүүдгүй байх байсан; иймийн тул тэд зовлонг мэдээгүйн учир, баяр баясал үгүй, гэм зэмгүй гэнэн байдалдаа үлдэх байсан; тэд нүглийг мэдэхгүй учир сайныг эс үйлдэх байсан билээ.

24 Гэвч болгоогтун, бүх зүйл, бүхнийг мэдэгч түүний мэргэн ухаанд хийгдсэн билээ.

25 Адам хүмүүн байж болохын тулд унасан; мөн тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө.

26 Мөн тэрээр хүмүүний үрсийг уналтаас гэтэлгэж болохын тулд, Мессиа цаг хугацааны бүрэн байдлын үед ирэх болно. Мөн тэд уналтаас гэтэлгэгдсэний учир тэд үүрдийн чөлөөт, сайныг муугаас ялгаж мэдэх болсон; өөрсдийн төлөө үйлдэх мөн Бурханы өгсөн зарлигуудын дагуу, агуу хийгээд эцсийн өдөр хуулийн шийтгэлээс бусдаар өөрсөд дээрээ үйлдүүлэх нь үгүй болой.

And after Adam and Eve had partaken of the forbidden fruit they were driven out of the garden of Eden, to till the earth.

And they have brought forth children; yea, even the family of all the earth.

And the days of the children of men were prolonged, according to the will of God, that they might repent while in the flesh; wherefore, their state became a state of probation, and their time was lengthened, according to the commandments which the Lord God gave unto the children of men. For he gave commandment that all men must repent; for he showed unto all men that they were lost, because of the transgression of their parents.

And now, behold, if Adam had not transgressed he would not have fallen, but he would have remained in the garden of Eden. And all things which were created must have remained in the same state in which they were after they were created; and they must have remained forever, and had no end.

And they would have had no children; wherefore they would have remained in a state of innocence, having no joy, for they knew no misery; doing no good, for they knew no sin.

But behold, all things have been done in the wisdom of him who knoweth all things.

Adam fell that men might be; and men are, that they might have joy.

And the Messiah cometh in the fulness of time, that he may redeem the children of men from the fall. And because that they are redeemed from the fall they have become free forever, knowing good from evil; to act for themselves and not to be acted upon, save it be by the punishment of the law at the great and last day, according to the commandments which God hath given.



- 27 Иймийн тул, хүмүүн нь бие махбодийн дагуу чөлөөт болой; мөн хүнд шаардлагатай болох бүх зүйл тэдэнд өгөгдсөн билээ. Мөн тэд бүх хүмүүний агуу их Зуучаар дамжуулан, эрх чөлөө болон мөнх амьдралыг сонгох эсвэл чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, боолчлол болон үхлийг сонгох эрхтэй; учир нь тэрээр бүх хүмүүн өөрийн адил зовлонт байж болохыг эрэлхийлдэг бөлгөө.
- 28 Мөн эдүгээ, хөвгүүд минь, та нарыг агуу их Зуучид найдан, мөн түүний агуу зарлигуудыг анхаараасай; мөн түүний үгсэд итгэлтэй байж, мөн түүний Ариун Сүнсний тааллын дагуу, мөнх амьдралыг сонгоосой хэмээнэ би;
- 29 Мөн тэрээр өөрийн хаант улсад та нарын дээр засаглаж болохын тулд, та нарыг доош тамд авчран боолчлох хүчийг чөтгөрийн сүнсэнд өгөх маханбодийн таалал мөн түүнд байх тэр хилэнцийн дагуу мөнхийн үхлийг бүү сонгоосой хэмээнэ.
- 30 Би эдгээр хэдэн үгсийг өөрийн хөвгүүд та бүгдэд хандан, өөрийн сорилтын эцсийн өдрүүдэд ярьсан билээ; мөн би бошиглогчийн үгсийн дагуу сайн хэсгийг сонгож авсан. Мөн та нарын бодгалиудын үүрдийн зол жаргалаас өөр эрмэлзэл надад байхгүй болой. Амен.

Wherefore, men are free according to the flesh; and all things are given them which are expedient unto man. And they are free to choose liberty and eternal life, through the great Mediator of all men, or to choose captivity and death, according to the captivity and power of the devil; for he seeketh that all men might be miserable like unto himself.

And now, my sons, I would that ye should look to the great Mediator, and hearken unto his great commandments; and be faithful unto his words, and choose eternal life, according to the will of his Holy Spirit;

And not choose eternal death, according to the will of the flesh and the evil which is therein, which giveth the spirit of the devil power to captivate, to bring you down to hell, that he may reign over you in his own kingdom.

I have spoken these few words unto you all, my sons, in the last days of my probation; and I have chosen the good part, according to the words of the prophet. And I have none other object save it be the everlasting welfare of your souls. Amen.

## 2 Нифай 3

- 1 Мөн эдүгээ отгон хүү Иосеф минь, би чамд хандан ярья. Чи миний зовлон зүдрэлийн аглаг буйдад төрсөн билээ; тийм ээ, миний хамгийн их харамсаж га шуудсан тэр өдрүүдэд эх чинь чамайг төрүүлсэн билээ.
- 2 Мөн хэрэв энэчлэн байж чи Израилын Ариун Нэгэний зарлигуудыг дагах аваас, чиний үүрдийн аюулгүй байдлын тулд чиний өв мөн ах нарынхтай чинь хамт үр удмын чинь өв болгохоор, хамгийн эрхэм сайхан нутаг болох, энэ нутгийг түүнчлэн Их Эзэн чамд ариулан адислах болтугай.
- 3 Мөн эдүгээ, Иосеф, зүдгүүрүүдийнхээ аглаг буйдаас миний авчирсан отгон хүү минь, Их Эзэн чамайг үүрд адислаг, өөрөөр хэлбэл чиний үр удам бүрмөсөн устгагдахгүй.
- 4 Учир нь болгоогтун, чи бол миний хэвлийн үр билээ; мөн бибээр Египетэд боолчлолд хүргэгдэж асан Иосефын удам бөлгөө. Мөн Иосефтой хийсэн Их Эзэний гэрээнүүд агуу юм.
- 5 Иймийн тул, Иосеф үнэхээр бидний үеийг харсан буюу. Мөн түүний хэвлийн гарсан үрсийг Их Эзэн Бурхан Израилын угсааны төлөө зөв шударга мөчир болгон өсгөнө гэсэн Их Эзэний амлалтыг тэрээр олж авсан буюу; Мессиа бус, харин хугарсан байх хэдий ч Их Эзэний гэрээнүүдэд санагдах нэгэн мөчир хожмын өдрүүдэд Мессиа тэдэнд хүч чадлын суу билгээр, тэднийг харанхуйгаас гэрэлд авчрахаар тэдэнд мэдүүлэгдэх гэсэн тэр—тийм ээ, нуугдмал харанхуйгаас мөн боолчлолоос эрх чөлөөнд болой.
- 6 Учир нь Иосеф үнэхээр гэрчилж, өгүүлсэн нь: Миний хэвлийн үрсээс сонгогдсон байх үзмэрчийг, Их Эзэн Бурхан минь тэр үзмэрчийг тодруулах болно.
- 7 Тийм ээ, Иосеф үнэхээр хэлэв: Их Эзэн надад ийн хэллээ: Би чиний хэвлийн үрсээс сонгогдсон үзмэрчийг тодруулна; мөн тэрээр чиний хэвлийн үрсийн дунд өндрөөр хүндлэгдэх болно. Мөн тэрээр өөрийн ах дүү нар болох чиний хэвлийн үрсийн хувьд, тэдэнд агуу үнэт болох, бүр миний эцэг өвгөдтэй чиний хийсэн тэр гэрээнүүдийн мэдлэгт тэднийг авчрах тэр ажлыг үйлдэхийг би түүнд зарлиг болгоно.

## 2 Nephi 3

And now I speak unto you, Joseph, my last-born. Thou wast born in the wilderness of mine afflictions; yea, in the days of my greatest sorrow did thy mother bear thee.

And may the Lord consecrate also unto thee this land, which is a most precious land, for thine inheritance and the inheritance of thy seed with thy brethren, for thy security forever, if it so be that ye shall keep the commandments of the Holy One of Israel.

And now, Joseph, my last-born, whom I have brought out of the wilderness of mine afflictions, may the Lord bless thee forever, for thy seed shall not utterly be destroyed.

For behold, thou art the fruit of my loins; and I am a descendant of Joseph who was carried captive into Egypt. And great were the covenants of the Lord which he made unto Joseph.

Wherefore, Joseph truly saw our day. And he obtained a promise of the Lord, that out of the fruit of his loins the Lord God would raise up a righteous branch unto the house of Israel; not the Messiah, but a branch which was to be broken off, nevertheless, to be remembered in the covenants of the Lord that the Messiah should be made manifest unto them in the latter days, in the spirit of power, unto the bringing of them out of darkness unto light—yea, out of hidden darkness and out of captivity unto freedom.

For Joseph truly testified, saying: A seer shall the Lord my God raise up, who shall be a choice seer unto the fruit of my loins.

Yea, Joseph truly said: Thus saith the Lord unto me: A choice seer will I raise up out of the fruit of thy loins; and he shall be esteemed highly among the fruit of thy loins. And unto him will I give commandment that he shall do a work for the fruit of thy loins, his brethren, which shall be of great worth unto them, even to the bringing of them to the knowledge of the covenants which I have made with thy fathers.

- 8 Мөн миний түүнд зарлиглах тэр ажлаас өөр, нэгэхэн ч ажлыг хийх ёсгүйг би түүнд зарлиг болгон өгөх болно. Мөн би түүнийг өөрийн мэлмийд агуу болгох болно; учир нь тэрээр миний ажлыг хийх бөлгөө.
- 9 Мөн тэрээр, хүмүүсийг минь чөлөөлнө, би та нарт тодруулна гэж миний хэлсэн тэр Мосегийн адил агуу байх болно, Ай Израилын угсаа.
- 10 Мөн чиний хүмүүсийг Египет нутгаас гаргахын тулд би Мосег тодруулах болно.
- 11 Гэвч би чиний хэвлийн үрсээс нэгэн үзмэрчийг тодруулна; мөн хэвлийн чинь үрд миний үгийг авчрах хүчийг би түүнд өгнө—мөн зөвхөн миний үгсийг авчрах бус, Их Эзэн хэлрүүн, харин аль хэдийн тэдний дунд очсон байх тэдгээр, миний үгсэд итгүүлэх хүчийг буюу.
- 12 Иймийн тул, хэвлийн чинь үрс бичиглэх болно; мөн Иудейн хэвлийн үрс бичиглэх болно; мөн чиний хэвлийн үрсээр бичигдэх тэр нь, мөн түүнчлэн Иудейн хэвлийн үрсээр бичигдэх тэр нь буруу сургаалуудыг бүрмөсөн үгүйсгэж мөн маргаан тэмцлийг намжаан, мөн хэвлийн чинь үрсийн дунд амар амгаланг тогтоон хамтран нэгдэх болно, мөн хожмын өдрүүдэд эцэг өвгөдийнх нь мэдлэгт тэднийг авчирна, мөн түүнчлэн миний гэрээнүүдийн мэдлэгт буюу хэмээн Их Эзэн хэлэв.
- 13 Мөн чиний сэргээлтэнд, Ай Израилын угсаа, миний ажил миний бүх хүмүүсийн дунд эхлэн үүсэх тэр өдөр тэрээр сул доройгоос чадалтай болгогдох болно хэмээн Их Эзэн өгүүлэв.
- 14 Мөн тэрчлэн Иосеф бошиглож, хэлсэн нь: Болгоогтун, уг үзмэрчийг Их Эзэн адислах болно; мөн түүнийг устгахыг эрэлхийлэх тэд устгагдах болно; учир нь хэвлийн минь үрсийн талаар, Их Эзэнээс миний олсон, энэ амлалт гүйцэлдэх болно. Болгоогтун, энэ амлалтын биелэлтийн талаар би огт эргэлзэхгүй байна;
- 15 Мөн түүний нэр минийхээр нэрлэгдэх болно; мөн энэ нь түүний эцгийн нэр байх болно. Мөн тэрээр надтай адил байх болно; уг зүйлийн учир түүний гараар Их Эзэн авчруулах, Их Эзэний хүчээр миний хүмүүсийг авралд авчрах болно.

And I will give unto him a commandment that he shall do none other work, save the work which I shall command him. And I will make him great in mine eyes; for he shall do my work.

And he shall be great like unto Moses, whom I have said I would raise up unto you, to deliver my people, O house of Israel.

And Moses will I raise up, to deliver thy people out of the land of Egypt.

But a seer will I raise up out of the fruit of thy loins; and unto him will I give power to bring forth my word unto the seed of thy loins—and not to the bringing forth my word only, saith the Lord, but to the convincing them of my word, which shall have already gone forth among them.

Wherefore, the fruit of thy loins shall write; and the fruit of the loins of Judah shall write; and that which shall be written by the fruit of thy loins, and also that which shall be written by the fruit of the loins of Judah, shall grow together, unto the confounding of false doctrines and laying down of contentions, and establishing peace among the fruit of thy loins, and bringing them to the knowledge of their fathers in the latter days, and also to the knowledge of my covenants, saith the Lord.

And out of weakness he shall be made strong, in that day when my work shall commence among all my people, unto the restoring thee, O house of Israel, saith the Lord.

And thus prophesied Joseph, saying: Behold, that seer will the Lord bless; and they that seek to destroy him shall be confounded; for this promise, which I have obtained of the Lord, of the fruit of my loins, shall be fulfilled. Behold, I am sure of the fulfilling of this promise;

And his name shall be called after me; and it shall be after the name of his father. And he shall be like unto me; for the thing, which the Lord shall bring forth by his hand, by the power of the Lord shall bring my people unto salvation.

16 Тийм ээ, тэрчлэн Иосеф бошиглов: бүр Мосегийн тухай амлалтанд би эргэлзээгүй шиг би үүнд эргэлзэхгүй байна; би чиний удмыг үүрд хадгалах болно хэмээн Их Эзэн надад хэлсний учир бөлгөө.

17 Мөн Их Эзэн хэлэв: Би Мосе гэгч нэгнийг тодруулах болно; мөн би түүнд саваанд хүчийг өгнө; мөн би түүнд бичиглэх чадварыг өгнө. Гэвч түүний хэлийг тэрээр ихийг ярихуйц тийм хэлэмгий болгохгүй, учир нь би түүнийг ярихаар чадамгай болгохгүй. Харин гарынхаа хуруугаар би түүнд өөрийн хуулийг бичих болно; мөн би түүний өмнөөс яригчийг тодруулах болно.

18 Мөн Их Эзэн надад түүнчлэн хэлэв: Би хэвлийн чинь үрсийн төлөө тодруулах болно; мөн би түүний өмнөөс яригч нэгнийг тодруулна. Мөн би, болгоогтун, би түүнд хэвлийн чинь удамд, чиний хэвлийн удмын бичиглэлийг бичих эрхийг өгөх болно; мөн чиний хэвлийн удмын яригч нэгэн үүнийг тунхаглах болно.

19 Мөн түүний бичих үгс нь хэвлийн чинь удамд очих ёстой миний мэргэн ухаанд нийцэх эдгээр үгс болой. Мөн энэ нь хэвлийн чинь удам газар шорооноос тэдэнд хашгирсан мэт байх болно; учир нь би тэдний итгэлийг мэднэ.

20 Мөн тэд газар шорооноос хашгирах болно; тийм ээ, бүр өөрсдийн ах дүүст наманчлалыг болой, бүр олон үе тэднээс хойш өнгөрсөн хойно ч гэсэн. Мөнхүү улиран тохиох дор тэдний хашгирах дуу хадах болно, бүр тэдний үгсийн энгийн хялбарын дагуу буюу.

21 Тэдний итгэлийн учир тэдний үгс миний амнаас гараад тэдний ах дүү нар болох хэвлийн чинь үрсэд очих болно; мөн би чиний эцэг өвгөдтэй хийсэн гэрээгээ санан би тэдний үгсийн сул доройг итгэлд нь хүчтэй болгоно.

22 Мөн эдүгээ, болгоогтун, хүү Иосеф минь, ийм маягаар миний өвөг бошиглосон болой.

23 Иймийн тул, энэ гэрээний учир чи адислагдсан болой; учир нь чиний үр удам уг номын үгсийг сонсохын тулд тэд устгагдахгүй байх бөлгөө.

Yea, thus prophesied Joseph: I am sure of this thing, even as I am sure of the promise of Moses; for the Lord hath said unto me, I will preserve thy seed forever.

And the Lord hath said: I will raise up a Moses; and I will give power unto him in a rod; and I will give judgment unto him in writing. Yet I will not loose his tongue, that he shall speak much, for I will not make him mighty in speaking. But I will write unto him my law, by the finger of mine own hand; and I will make a spokesman for him.

And the Lord said unto me also: I will raise up unto the fruit of thy loins; and I will make for him a spokesman. And I, behold, I will give unto him that he shall write the writing of the fruit of thy loins, unto the fruit of thy loins; and the spokesman of thy loins shall declare it.

And the words which he shall write shall be the words which are expedient in my wisdom should go forth unto the fruit of thy loins. And it shall be as if the fruit of thy loins had cried unto them from the dust; for I know their faith.

And they shall cry from the dust; yea, even repentance unto their brethren, even after many generations have gone by them. And it shall come to pass that their cry shall go, even according to the simpleness of their words.

Because of their faith their words shall proceed forth out of my mouth unto their brethren who are the fruit of thy loins; and the weakness of their words will I make strong in their faith, unto the remembering of my covenant which I made unto thy fathers.

And now, behold, my son Joseph, after this manner did my father of old prophesy.

Wherefore, because of this covenant thou art blessed; for thy seed shall not be destroyed, for they shall hearken unto the words of the book.

24 Мөн Израилын угсааныханд мөн чиний ах нарын үр удамд машид их сэргээлтийг улируулан авчрах, мөн Бурханы мэлмийд агуу их болох тэр зүйлийг хийх, мөн хүчит гайхамшгуудыг үйлдэх, нэтэд их итгэлийг агуулж, Бурханы мутарт зэмсэг байснаар, үгээр болон үйлээр аль алинаар нь ихэд сайныг хийх тэрхүү хүчит нэгэн тэдний дунд тодрох болно.

25 Мөн эдүгээ, адислагдсан болой чи, Иосеф. Болгоогтун чи бол бага; иймийн тул ах Нифайнхаа үгэнд орж бай, ингээд энэ нь бүр миний ярьсан тэдгээр үгсийн дагуу гүйцэтгэгдэх болно. Наснаас хальж буй эцгийнхээ үгсийг сана. Амен.

And there shall rise up one mighty among them, who shall do much good, both in word and in deed, being an instrument in the hands of God, with exceeding faith, to work mighty wonders, and do that thing which is great in the sight of God, unto the bringing to pass much restoration unto the house of Israel, and unto the seed of thy brethren.

And now, blessed art thou, Joseph. Behold, thou art little; wherefore hearken unto the words of thy brother, Nephi, and it shall be done unto thee even according to the words which I have spoken. Remember the words of thy dying father. Amen.

## 2 Нифай 4

- 1 Мөн эдүгээ, би, Нифай, Египетэд аваачигдсан Иосефын талаар, эцгийнхээ ярьсан бошиглолуудын талаар өгүүлье.
- 2 Учир нь болгоогтун, тэрээр үнэхээр өөрийн бүх үр удмын талаар бошиглосон болой. Мөн түүний бичсэн бошиглолуудаас, илүү чухал олон нь үгүй бөлгөө. Мөн тэрээр бидний тухай, мөн бидний ирээдүйн үеүдийн талаар бошиглов; мөн тэдгээр нь гуулин ялтсууд дээр бичигдсэн болой.
- 3 Иймийн тул, миний эцэг Иосефын бошиглолуудын талаар ярьснаа төгсгөл болгосны дараа, тэрээр Лемений хүүхдүүдийг, түүний хөвгүүд, мөн түүний охидыг дуудаж, мөн тэдэнд хандан: Болгоогтун, миний ууган хүүгийн хөвгүүд болон охид болох хөвгүүд минь, мөн охид минь, та нарыг миний үгсийг чих та вин сонсоосой хэмээнэ би.
- 4 Учир нь Их Эзэн Бурхан ийн хэлэв: Та нар миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжинэ; харин та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар миний дэргэдээс тусгаарлагдах болно.
- 5 Гэвч болгоогтун, хөвгүүд минь мөн охид минь, би та нарын дээр адислал үлдээлгүйгээр булшиндаа одож чадахгүй; учир нь болгоогтун, хэрэв та нар өөрсдийн явбал зохих тэр зам дээр өсгөгдсөн бол та нар үүнээс хагацахгүйг би мэдэж байна.
- 6 Иймийн тул, хэрэв та нар зүхэгдэх аваас, болгоогтун, тэр зүхэл та нараас зайлуулагдаж мөн та нарын эцэг эхийн толгой дээр хариулагдахын тулд би адислалаа та нар дээр үлдээж байна.
- 7 Иймийн тул, миний адислалын учир Их Эзэн Бурхан та нарыг эрсдэхийг зөвшөөрөхгүй; иймийн тул, тэрээр та нарт мөн та нарын үр удамд үүрд нигүүлсэнгүй хандах болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг Лемений хөвгүүд, охидод ярьснаа төгсгөл болгосны дараа, тэрээр Лемүелийн хөвгүүд, охидыг өөрийнхөө өмнө ирүүлэв.

## 2 Nephi 4

And now, I, Nephi, speak concerning the prophecies of which my father hath spoken, concerning Joseph, who was carried into Egypt.

For behold, he truly prophesied concerning all his seed. And the prophecies which he wrote, there are not many greater. And he prophesied concerning us, and our future generations; and they are written upon the plates of brass.

Wherefore, after my father had made an end of speaking concerning the prophecies of Joseph, he called the children of Laman, his sons, and his daughters, and said unto them: Behold, my sons, and my daughters, who are the sons and the daughters of my firstborn, I would that ye should give ear unto my words.

For the Lord God hath said that: Inasmuch as ye shall keep my commandments ye shall prosper in the land; and inasmuch as ye will not keep my commandments ye shall be cut off from my presence.

But behold, my sons and my daughters, I cannot go down to my grave save I should leave a blessing upon you; for behold, I know that if ye are brought up in the way ye should go ye will not depart from it.

Wherefore, if ye are cursed, behold, I leave my blessing upon you, that the cursing may be taken from you and be answered upon the heads of your parents.

Wherefore, because of my blessing the Lord God will not suffer that ye shall perish; wherefore, he will be merciful unto you and unto your seed forever.

And it came to pass that after my father had made an end of speaking to the sons and daughters of Laman, he caused the sons and daughters of Lemuel to be brought before him.

- 9 Мөн тэрээр тэдэнд хандан, өгүүлсэн нь: Болгоогтун, миний хоёр дахь хүүгийн хөвгүүд, охид боло хөвгүүд минь, мөн охид минь; болгоогтун, Лемений хөвгүүд, охидод үлдээсний адил адислалыг би та нарт үлдээе; иймийн тул, та нар тэр чигээрээ устгагдахгүй; харин эцэст нь таны үр удам адислагдах болно.
- 10 Мөнхүү улиран тохиох дор эцэг минь тэдэнд ярьснаа төгсгөл болгоход, болгоогтун, тэрээр Ишмэилийн хөвгүүдэд хандан ярив, тийм ээ, мөн түүгээр үл барам түүний гэрийнхэнд бүгдэд нь бөлгөө.
- 11 Мөн тэрээр тэдэнд хандан ярьснаа төгсгөл болгосны дараа, тэрээр Самд хандан ярьж, өгүүлсэн нь: Чи болон чиний үр удам адислагдсан болой; чи дүү Нифайнхаа адил уг нутгийг өвлөхийн учир буюу. Мөн чиний үр удам түүний үр удамтай хамт тоологдох болно; мөн чи дүүгийнхээ нэгэн адил бай, мөн чиний үр удам түүний үр удмын адил байж; мөн чи өөрийн бүх өдрүүдэд адислагдах болно.
- 12 Мөнхүү улиран тохиох дор миний эцэг, Лихай, түүнд орших Их Эзэний Сүнс мөн өөрийн зүрх сэтгэлийн мэдрэмжийн дагуу, өөрийнхөө гэрийнхэнд бүгдэд нь ярьсны дараа, тэрээр өндөр настай болжээ. Мөнхүү улиран тохиох дор тэрээр нас нөгчиж, оршуулагдсан болой.
- 13 Мөнхүү улиран тохиох дор түүнийг нас нөгчсөнөөс хойш хэдхэн хоногийн дараа, Лемен Лемүел хоёр бас Ишмэилийн хөвгүүд Их Эзэний зэмлэлийн улмаас надад уурлаж байлаа.
- 14 Учир нь би, Нифай түүний үгийн дагуу, тэдэнд хандан ярихаар албадуулсан билээ; тухайлбал би тэдэнд олон зүйлийг ярьсан байв, мөн түүнчлэн миний эцэг нас нөгчихийн өмнө буюу; хэлсэн тэдгээрээс олон нь миний нөгөө ялтсууд дээр бичигдсэн билээ; миний нөгөө ялтсууд дээр илүү түүхэн хэсэг нь бичигдсэний учир нь энэ болой.
- 15 Мөн эдгээрийн дээр өөрийн дотоод сэтгэлийн зүйлийг мөн гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэдгээр судруудын олныг би бичих ажгуу. Учир нь дотоод сэтгэл минь судруудад баясна, мөн зүрх минь тэдгээрийг тунгаан, мөн хүүхдүүдийнхээ эрдэм хийгээд тусын тулд тэдгээрийг бичиглэх бөлгөө.

And he spake unto them, saying: Behold, my sons and my daughters, who are the sons and the daughters of my second son; behold I leave unto you the same blessing which I left unto the sons and daughters of Laman; wherefore, thou shalt not utterly be destroyed; but in the end thy seed shall be blessed.

And it came to pass that when my father had made an end of speaking unto them, behold, he spake unto the sons of Ishmael, yea, and even all his household.

And after he had made an end of speaking unto them, he spake unto Sam, saying: Blessed art thou, and thy seed; for thou shalt inherit the land like unto thy brother Nephi. And thy seed shall be numbered with his seed; and thou shalt be even like unto thy brother, and thy seed like unto his seed; and thou shalt be blessed in all thy days.

And it came to pass after my father, Lehi, had spoken unto all his household, according to the feelings of his heart and the Spirit of the Lord which was in him, he waxed old. And it came to pass that he died, and was buried.

And it came to pass that not many days after his death, Laman and Lemuel and the sons of Ishmael were angry with me because of the admonitions of the Lord.

For I, Nephi, was constrained to speak unto them, according to his word; for I had spoken many things unto them, and also my father, before his death; many of which sayings are written upon mine other plates; for a more history part are written upon mine other plates.

And upon these I write the things of my soul, and many of the scriptures which are engraven upon the plates of brass. For my soul delighteth in the scriptures, and my heart pondereth them, and writeth them for the learning and the profit of my children.

16 Болгоогтун, сэтгэл минь Их Эзэний зүйлүүдэд баясч; мөн зүрх минь өөрийн үзсэн мөн сонссон зүйлийг үргэлж тунгаадаг.

17 Гэсэн хэдий ч, түүний агуу хийгээд гайхамшигт ажлуудыг надад үзүүлэх Их Эзэний агуу сайн сайхан байлаа ч, зүрх минь хашгирч: Ай золгүй хүн юм би! Тийм ээ зүрх минь маханбодийнхоо учир харуусч; бодгаль минь миний алдсуудын учир гашуудах ажгуу.

18 Би хүрээлэгдсэн нэгэн, намайг туйлын амархнаар хавчих тэр уруу таталтууд болон нүглүүдийн улмаас болой.

19 Мөн намайг баясахыг хүсэхээр миний нүглүүдийн учир зүрх минь ёлно; гэсэн хэдий ч, би хэнд итгэснээ мэдэж байна.

20 Миний Бурхан миний дэмжлэг байсан; тэрээр аглаг буйд дахь зовлонгуудын минь дундуур намайг удирдсан; мөн тэрээр гүн далай дээр намайг хамгаалсан билээ.

21 Тэрээр намайг хайраараа дүүргэв, бүр бүх бие минь төөнөгдтөл буюу.

22 Тэрээр миний дайснуудыг, миний өмнө салгалах хүртэл нь тэднийг гутаасан буюу.

23 Болгоогтун, тэрээр өдөр гуйлтыг минь сонсож, мөн тэрээр надад шөнийн цагт үзэгдлүүдээр мэдлэг өгсөн болой.

24 Мөн түүний өмнөх хүчит залбирлууддаа би өдрөөр зориг төрдөг байв; тийм ээ, дуу хоолойгоо би дээдэд илгээсэн; мөн тэнгэр элчүүд доош ирж, надад тохинуулсан бөлгөө.

25 Мөн түүний Сүнсний далавчнууд дээр миний бие үлэмж өндөр уулсын дээр аваачигдсан болой. Мөн нүд минь агуу их зүйлийг болгоосон, тийм ээ, бүр хүмүүнд ахадхуйц агуу ихийг буюу; тиймийн тул би тэдгээрийг бичихгүй байхаар зарлигдуулсан болой.

26 Ай тэгээд, хэрэв би тийм агуу их зүйлийг харж байсан юм бол, хэрэв Их Эзэн хүмүүний үрсэд хандуулсан хүлцэлдээ тийм их нигүүлслээр айлчилсан юм бол, яагаад зүрх сэтгэл минь шархирч мөн бодгаль минь гунигийн хөндийд хоргодон, мөн маханбодь минь эцэн, бас хүч чадал минь зүдгүүрүүдийнхээ учир сулрах билээ

Behold, my soul delighteth in the things of the Lord; and my heart pondereth continually upon the things which I have seen and heard.

Nevertheless, notwithstanding the great goodness of the Lord, in showing me his great and marvelous works, my heart exclaimeth: O wretched man that I am! Yea, my heart sorroweth because of my flesh; my soul grieveth because of mine iniquities.

I am encompassed about, because of the temptations and the sins which do so easily beset me.

And when I desire to rejoice, my heart groaneth because of my sins; nevertheless, I know in whom I have trusted.

My God hath been my support; he hath led me through mine afflictions in the wilderness; and he hath preserved me upon the waters of the great deep.

He hath filled me with his love, even unto the consuming of my flesh.

He hath confounded mine enemies, unto the causing of them to quake before me.

Behold, he hath heard my cry by day, and he hath given me knowledge by visions in the night-time.

And by day have I waxed bold in mighty prayer before him; yea, my voice have I sent up on high; and angels came down and ministered unto me.

And upon the wings of his Spirit hath my body been carried away upon exceedingly high mountains. And mine eyes have beheld great things, yea, even too great for man; therefore I was bidden that I should not write them.

O then, if I have seen so great things, if the Lord in his condescension unto the children of men hath visited men in so much mercy, why should my heart weep and my soul linger in the valley of sorrow, and my flesh waste away, and my strength slacken, because of mine afflictions?



27 Мөн өөрийн маханбодийн учир яагаад би нүгэлд бууж өгөх билээ? Тийм ээ, миний амгаланг устган мөн бодгалийг минь зовоох тэр хилэнцэт нэгнийг зүрх сэтгэлдээ байрлуулан, уруу таталтанд би яагаад зам тавих билээ? Би яагаад дайсныхаа учир уурлах билээ

28 Бодгаль минь, сэр! Дахин битгий нүгэлд гудай. Баяс, Ай зүрх сэтгэл минь, мөн бодгалийн минь дайсанд дахин битгий зай тавь.

29 Миний дайснуудын улмаас дахин битгий бухимд. Зовлонгуудынхаа учир хүчийг минь битгий сулруул.

30 Баяс, Ай зүрх сэтгэл минь, мөн Их Эзэнд залбиран гуй, мөн хэл: Ай Их Эзэн, би таныг үүрд магтан дуулах болно; тийм ээ миний сүнс танд баясна, Бурхан минь, мөн авралын минь хад билээ.

31 Ай Их Эзэн, та сүнсийг минь гэтэлгэнэ үү? Та дайснуудын минь гараас намайг чөлөөлнө үү? Та намайг нүглийг хараад чичрэх нэгэн болгоно уу

32 Миний өмнө тамын хаалга үргэлж хаалттай байг, зүрх сэтгэл минь харуусч мөн бодгаль минь гэмшсэний учир буюу! Ай Их Эзэн, та зөв шударгынхаа хаалгуудыг миний өмнө бүү хаагаач, би дорд хөндийн замаар алхаж болохын тулд, би энгийн замд шулуун байж болохын тулд буюу!

33 Ай Их Эзэн, зөв шударгын орхимжоороо намайг ороогооч! Ай Их Эзэн, дайснуудынхаа өмнө зугтах замыг минь бэлтгээч! Та өмнөх замыг минь надад шулуутгаж өгөөч! Та замд минь тээглэх чулуу бүү байрлуулаач—харин өмнөх замыг минь бартаагүй байлгаач, мөн замд минь саад бүү босгооч, харин дайсны минь замд бөлгөө.

34 Ай Их Эзэн, би танд найдсан билээ, мөн би танд үүрд найдах болно. Би найдлагаа маханбодийн гарт тавих нь үгүй; учир нь найдлагаа маханбодийн гарт тавьдаг тэрээр зүхэгддэгийг би мэднэ. Тийм ээ, найдлагаа хүмүүнд тавьдаг буюу маханбодийг гараа болгох тэрбээр зүхэгддэг болой.

And why should I yield to sin, because of my flesh? Yea, why should I give way to temptations, that the evil one have place in my heart to destroy my peace and afflict my soul? Why am I angry because of mine enemy?

Awake, my soul! No longer droop in sin. Rejoice, O my heart, and give place no more for the enemy of my soul.

Do not anger again because of mine enemies. Do not slacken my strength because of mine afflictions.

Rejoice, O my heart, and cry unto the Lord, and say: O Lord, I will praise thee forever; yea, my soul will rejoice in thee, my God, and the rock of my salvation.

O Lord, wilt thou redeem my soul? Wilt thou deliver me out of the hands of mine enemies? Wilt thou make me that I may shake at the appearance of sin?

May the gates of hell be shut continually before me, because that my heart is broken and my spirit is contrite! O Lord, wilt thou not shut the gates of thy righteousness before me, that I may walk in the path of the low valley, that I may be strict in the plain road!

O Lord, wilt thou encircle me around in the robe of thy righteousness! O Lord, wilt thou make a way for mine escape before mine enemies! Wilt thou make my path straight before me! Wilt thou not place a stumbling block in my way—but that thou wouldst clear my way before me, and hedge not up my way, but the ways of mine enemy.

O Lord, I have trusted in thee, and I will trust in thee forever. I will not put my trust in the arm of flesh; for I know that cursed is he that putteth his trust in the arm of flesh. Yea, cursed is he that putteth his trust in man or maketh flesh his arm.

35 Тийм ээ, гуйсан нэгэнд Бурхан өгөөмрөөр соёрхох болно гэдгийг би мэднэ. Тийм ээ, Бурхан минь надад соёрхох болно, хэрэв би бурууг гуйхгүй аваас; тиймийн тул би дуу хоолойгоо танд хандан өргөх болно; тийм ээ, Бурхан минь, миний зөв шударгын хад, би танд хандан залбиран гуйх болно.  
Болгоогтун, дуу хоолой минь үүрд танд хандан дээш одох болно, миний хад, мөн миний үүрдийн Бурханд буюу. Амен.

Yea, I know that God will give liberally to him that asketh. Yea, my God will give me, if I ask not amiss; therefore I will lift up my voice unto thee; yea, I will cry unto thee, my God, the rock of my righteousness. Behold, my voice shall forever ascend up unto thee, my rock and mine everlasting God. Amen.

## 2 Нифай 5

- 1 Болгоогтун, улиран тохиох дор би, Нифай, Их Эзэн Бурхандаа ихэд залбиран гуйв, миний ах нарын уур омгийн учир бөлгөө.
- 2 Гэвч болгоогтун, тэдний уур омог миний эсрэг нэмэгдсээр байв, үүнийхээ хэрээр тэд миний амийг авахаар эрэлхийлсэн болой.
- 3 Тийм ээ, тэд миний эсрэг бувтналдаж, өгүүлсэн нь: Дүү маань биднийг захиран удирдахыг бодож байна; мөн бид түүнээс болж энэ их бэрхийг туулав; иймийн тул, түүний үгсийн учир дахин зовохгүй байж болохын тулд эдүгээ бүгдээрээ түүнийг алъя. Учир нь болгоогтун, бид түүнийг захирагчаа болгохгүй; учир нь энэ хүмүүсийг захирах нь, ах нар нь болох бидэнд хамаарагдана.
- 4 Эдүгээ би эдгээр ялтсууд дээр миний эсрэг бувтналдсан тэдний бүх үгсийг бичихгүй. Гэвч тэд амийг минь авахаар эрэлхийлж байсныг хэлэх нь надад хангалттай.
- 5 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, мөн надтай явах тэд бүгд тэднээс зайлан мөн аглаг буйд тийш зугтахыг Их Эзэн надад сэрэмжлүүлсэн билээ.
- 6 Иймийн тул, улиран тохиох дор би, Нифай, өөрийн гэр бүлийг, мөн түүнчлэн Зорам болон түүний гэр бүлийг, мөн миний ах Сам болон түүний гэр бүлийг, мөн түүнчлэн миний дүү нар болох Иаков бас Иосеф, мөн түүнчлэн миний эгч нар, мөн надтай явах тэд бүгдийг авлаа. Мөн надтай хамт явах тэд бүгд Бурханы илчлэлт хийгээд сануулгад итгэсэн тэд билээ; иймийн тул, тэд миний үгсийг анхааран сонсов.
- 7 Мөн бид майхнуудаа мөн бидэнд боломжтой гэгдсэн бүх зүйлийг авч, мөн аглаг буйдад олон өдрийн турш зорчив. Мөн бид олон өдрийн турш аялсныхаа дараа бид майхнуудаа босгов.
- 8 Мөн миний хүмүүс уг газрыг бид Нифай гэж нэрлэн дуудвал зохино хэмээв; иймийн тул, бид үүнийг Нифай гэж нэрлэв.
- 9 Мөн надтай байсан тэд бүгд өөрсдийгөө Нифайн хүмүүс гэж дуудуулахаар өөрсөд дээрээ уг нэрийг авав.

## 2 Nephi 5

Behold, it came to pass that I, Nephi, did cry much unto the Lord my God, because of the anger of my brethren.

But behold, their anger did increase against me, inso-much that they did seek to take away my life.

Yea, they did murmur against me, saying: Our younger brother thinks to rule over us; and we have had much trial because of him; wherefore, now let us slay him, that we may not be afflicted more because of his words. For behold, we will not have him to be our ruler; for it belongs unto us, who are the elder brethren, to rule over this people.

Now I do not write upon these plates all the words which they murmured against me. But it sufficeth me to say, that they did seek to take away my life.

And it came to pass that the Lord did warn me, that I, Nephi, should depart from them and flee into the wilderness, and all those who would go with me.

Wherefore, it came to pass that I, Nephi, did take my family, and also Zoram and his family, and Sam, mine elder brother and his family, and Jacob and Joseph, my younger brethren, and also my sisters, and all those who would go with me. And all those who would go with me were those who believed in the warnings and the revelations of God; wherefore, they did hearken unto my words.

And we did take our tents and whatsoever things were possible for us, and did journey in the wilderness for the space of many days. And after we had journeyed for the space of many days we did pitch our tents.

And my people would that we should call the name of the place Nephi; wherefore, we did call it Nephi.

And all those who were with me did take upon them to call themselves the people of Nephi.

- 10 Мөн бид Их Эзэний тогтоолуудыг мөн дүрмүүдийг, бас зарлигуудыг бүх зүйлүүдэд, Мосегийн хуулийн дагуу даган мөрдөж байсан бөлгөө.
- 11 Мөн Их Эзэн бидэнтэй хамт байв, мөн бид үлэмж дэгжин байв; учир нь бид үр тарьж, мөн бид эргээд элбэг их ургац хурааж байв. Мөн бид бог, мөн бод мал, бас төрөл бүрийн амьтдыг өсгөж эхлэв.
- 12 Мөн би, Нифай, түүнчлэн гуулин ялтсууд дээр сийлэгдсэн тэдгээр цэдгүүдийг, мөн түүнчлэн бичиглэгдсэний дагуу Их Эзэний мутраар миний эцэгт бэлтгэгдсэн тэр бөмбөрцөг өөрөөр хэлбэл лужинг авчирсан буюу.
- 13 Мөнхүү улиран тохиох дор бид үлэмж дэвжиж, мөн уг нутагт өнөржиж эхлэв.
- 14 Мөн би, Нифай, эдүгээ леменчүүд гэж нэрлэгдсэн тэдгээр хүмүүс биднийг довтолж мөн биднийг устгах бий хэмээснээс Лебений илдийг авч, үүний загвараар олон илд үйлдэв; учир нь миний зүг мөн хүүхдүүд минь мөн хүмүүс маань гэж нэрлэгдсэн тэдний зүг тэдний занал чиглэж буйг би мэдсэн бөлгөө.
- 15 Мөн барилгуудыг барихад, мөн бүх төрлийн модны ажилд, мөн төмөр, мөн зэс, мөн гууль, мөн ган, мөн алт, бас мөнгөний, бас машинд элбэг дэлбэг байх үнэт хүдрүүдийн ажилд би өөрийн хүмүүсийг сурсан билээ.
- 16 Мөн би, Нифай, ариун сүм босгов; мөн би үүнийг тийм олон үнэт зүйлээр барихаас бусдаар бол Соломоны ариун сүмийн маягаар дуурайлган барив; учир нь тэдгээр нь уг нутгаас олдсонгүй, иймийн тул, энэ нь Соломоны ариун сүм шиг баригдаж чадсангүй. Гэвч барилгын төрх байдал нь Соломоны ариун сүмтэй адил байв; мөн үүний урхийц үлэмж сайн байсан бөлгөө.
- 17 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, өөрийн хүмүүсийг хөдөлмөрч байлгаж, мөн өөрсдийнх нь гараар ажиллуулж байлаа.
- 18 Мөнхүү улиран тохиох дор тэд намайг хаанаа болгох гэв. Гэвч би, Нифай, тэд хаангүй байхыг хүсч байлаа; гэсэн хэдий ч, би тэдний төлөө хүч хүрэх бүхнээ хийсэн билээ.

And we did observe to keep the judgments, and the statutes, and the commandments of the Lord in all things, according to the law of Moses.

And the Lord was with us; and we did prosper exceedingly; for we did sow seed, and we did reap again in abundance. And we began to raise flocks, and herds, and animals of every kind.

And I, Nephi, had also brought the records which were engraven upon the plates of brass; and also the ball, or compass, which was prepared for my father by the hand of the Lord, according to that which is written.

And it came to pass that we began to prosper exceedingly, and to multiply in the land.

And I, Nephi, did take the sword of Laban, and after the manner of it did make many swords, lest by any means the people who were now called Lamanites should come upon us and destroy us; for I knew their hatred towards me and my children and those who were called my people.

And I did teach my people to build buildings, and to work in all manner of wood, and of iron, and of copper, and of brass, and of steel, and of gold, and of silver, and of precious ores, which were in great abundance.

And I, Nephi, did build a temple; and I did construct it after the manner of the temple of Solomon save it were not built of so many precious things; for they were not to be found upon the land, wherefore, it could not be built like unto Solomon's temple. But the manner of the construction was like unto the temple of Solomon; and the workmanship thereof was exceedingly fine.

And it came to pass that I, Nephi, did cause my people to be industrious, and to labor with their hands.

And it came to pass that they would that I should be their king. But I, Nephi, was desirous that they should have no king; nevertheless, I did for them according to that which was in my power.

- 19 Мөн болгоогтун, намайг тэдний захирагч мөн тэдний багш байна хэмээн Их Эзэн тэдний талаар ярьсан тэдгээр үгс ах нарын минь хувьд гүйцэлдсэн болой. Иймийн тул, би Их Эзэний зарлигуудын дагуу, тэд миний амийг авахаар эрэлхийлсэн цагийг хүртэл, би тэдний захирагч мөн тэдний багш байсан билээ.
- 20 Иймийн тул, надад хандан ярьсан Их Эзэний үг гүйцэлдсэн бөлгөө, өгүүлсэн нь: Тэд чиний үгийг дуулахгүй байхын хэрээр тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах болно. Мөн болгоогтун, тэд түүний дэргэдээс тусгаарлагдсан болой.
- 21 Мөн тэрээр зүхлийг тэдний дээр ирүүлжээ, тийм ээ, бүр зовлонт зүхлийг, тэдний алдсын улмаас бөлгөө. Учир нь болгоогтун, тэд зүрх сэтгэлээ түүний эсрэг хатууруулсны учир, тэд цахиур чулуу лугаа адил болсон байв; иймийн тул, тэдэнд байсан цагаан мөн үлэмж хонгор мөн бахдам сайхан нь, тэд миний хүмүүсийн дурыг булаам биш байж болохын тулд Их Эзэн Бурхан тэдний дээр арьс нь харлах учрыг хийжээ.
- 22 Мөн Их Эзэн Бурхан тийн хэлэв: Тэд алдсуудаа наманчлахаас бусдаар би тэднийг чиний хүмүүсийн хувьд зэвүүцэм муухай болгох болно.
- 23 Мөн тэдний үр удамтай холилдогч түүний үр удам зүхэгдэх болно; өөрөөр хэлбэл тэд бүр нэгэн адил зүхлээр зүхэгдэх болно. Мөн Их Эзэн үүнийг хэлсэн, мөн энэ нь хийгдсэн болой.
- 24 Мөн тэдний дээр байсан тэдний тэрхүү зүхлийн учир, тэд аюул болон зальт аргаар дүүрэн, залхуу хүмүүс болоод, аглаг буйдад идэшний амьтан эрж бэдрэх болов.
- 25 Мөн Их Эзэн Бурхан надад хандан хэлэв: Тэд чиний үр удамд намайг сануулахаар өдөөн хатгах цээрлэл болно; мөн тэд намайг санахгүй мөн миний үгсийг анхаарахгүй байхын хэрээр, тэднийг бүр устгалд нь хүртэл тэд цээрлүүлэх болно.
- 26 Мөнхүү улиран тохиох дор би, Нифай, миний хүмүүсийн нутаг даяар тэд санваартнууд мөн багш нар байхын тулд Иаков Иосеф хоёрыг томилон адислав.
- 27 Мөнхүү улиран тохиох дор бид аз жаргалтай хүмүүний ёсоор амьдарч байлаа.

And behold, the words of the Lord had been fulfilled unto my brethren, which he spake concerning them, that I should be their ruler and their teacher. Wherefore, I had been their ruler and their teacher, according to the commandments of the Lord, until the time they sought to take away my life.

Wherefore, the word of the Lord was fulfilled which he spake unto me, saying that: Inasmuch as they will not hearken unto thy words they shall be cut off from the presence of the Lord. And behold, they were cut off from his presence.

And he had caused the cursing to come upon them, yea, even a sore cursing, because of their iniquity. For behold, they had hardened their hearts against him, that they had become like unto a flint; wherefore, as they were white, and exceedingly fair and delightsome, that they might not be enticing unto my people the Lord God did cause a skin of blackness to come upon them.

And thus saith the Lord God: I will cause that they shall be loathsome unto thy people, save they shall repent of their iniquities.

And cursed shall be the seed of him that mixeth with their seed; for they shall be cursed even with the same cursing. And the Lord spake it, and it was done.

And because of their cursing which was upon them they did become an idle people, full of mischief and subtlety, and did seek in the wilderness for beasts of prey.

And the Lord God said unto me: They shall be a scourge unto thy seed, to stir them up in remembrance of me; and inasmuch as they will not remember me, and hearken unto my words, they shall scourge them even unto destruction.

And it came to pass that I, Nephi, did consecrate Jacob and Joseph, that they should be priests and teachers over the land of my people.

And it came to pass that we lived after the manner of happiness.

- 28 Мөн бид Иерусалимыг орхисон цагаас хойш гучин жил улирч одов.
- 29 Мөн би, Нифай, өөрийн хийсэн ялтсууд дээр өдийг хүртэл өөрийн хүмүүсийн цэдгүүдийг үлдээсээр байлаа.
- 30 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан надад хандан хэлэв: Өөр ялтсуудыг хий; мөн чи тэдний дээр миний мэлмийд сайн гэгдэх олон зүйлийг, өөрийн хүмүүсийн тусын тулд сийлбэрлэх бөлгөө.
- 31 Иймийн тул, би, Нифай, Их Эзэний зарлигуудад дуулгавартай байхын төлөө, явж мөн эдгээр зүйлүүдийг би дээр нь сийлсэн эдгээр ялтсуудыг хийсэн болой.
- 32 Мөн би Бурханы хувьд таалалтайг сийлбэрлэсэн бөлгөө. Мөн хэрэв миний хүмүүс Бурханы зүйлүүдэд таалалтай байх аваас эдгээр ялтсууд дээрх миний сийлбэрүүд тэдэнд таалагдах болно.
- 33 Мөн хэрэв миний хүмүүсийн түүхийн илүү тодорхой хэсгүүдийг мэдэхийг миний хүмүүс хүсвэл тэд миний нөгөө ялтсуудыг судлах ёстой болно.
- 34 Мөн дөчин жил улиран өнгөрч мөн бид хэдийн ах нартайгаа дайтаж мөн тэмцэлдэж байсныг хэлэх нь миний хувьд хангалттай буюу.

And thirty years had passed away from the time we left Jerusalem.

And I, Nephi, had kept the records upon my plates, which I had made, of my people thus far.

And it came to pass that the Lord God said unto me: Make other plates; and thou shalt engraven many things upon them which are good in my sight, for the profit of thy people.

Wherefore, I, Nephi, to be obedient to the commandments of the Lord, went and made these plates upon which I have engraven these things.

And I engraved that which is pleasing unto God. And if my people are pleased with the things of God they will be pleased with mine engravings which are upon these plates.

And if my people desire to know the more particular part of the history of my people they must search mine other plates.

And it sufficeth me to say that forty years had passed away, and we had already had wars and contentions with our brethren.

## 2 Нифай 6

- 1 Нифайн хүмүүст түүний хандан ярьсан Нифайн дүү болох, Иаковын үгс:
  - 2 Болгоогтун, миний хайрт ах дүү нар минь, би, Иаков, Бурханаар дуудагдаж, мөн түүний ариун жагсийн дагуу томилогдсон, мөн хаан эсвэл хамгаалагч мэт та нарын үздэг, мөн та нар аюулгүй байдлаа даатгадаг, өөрийн ах болох Нифайгаар томилогдон адислагдсаны учир, болгоогтун би та нарт хандан үлэмж олон зүйл ярьж байсныг та нар мэднэ.
  - 3 Гэсэн хэдий ч, би та нарт хандан дахин ярья; учир нь би та нарын сүнснүүдийн зол жаргалыг хүснэ. Тийм ээ, та нарын төлөө миний зовнил асар их байна; мөн үргэлж ийм байсныг та нар өөрсдөө мэднэ. Учир нь би та нарыг байдгаараа хичээнгүйлэн ухуулсан болой; мөн та нарт эцгийнхээ үгсийг заасан буюу би; мөн та нарт хандан энэ дэлхийн бүтээлтээс эхлэн бичигдсэн тэдгээр бүх зүйлийн талаар ярьсан буюу би.
  - 4 Мөн эдүгээ, болгоогтун, би та нарт хандан, байгаа мөн ирэх тэдгээр зүйлүүдийн талаар ярих болно; иймийн тул, би та нарт Исаиагийн үгсийг унших болно. Мөн тэдгээр нь та нарт намайг хандан ярихыг хүссэн ахын минь үгс болой. Мөн өөрсдийнхөө төлөө, та нар Бурханыхаа нэрийг мэдэж мөн алдаршуулж болохын учир би та нарт ярих ажгуу.
  - 5 Мөн эдүгээ, миний унших үгс болох тэдгээр нь бүх Израилын угсааны талаар Исаиагийн ярьсан нь бөлгөө; иймийн тул, та нар Израилын угсааных учир, тэдгээр нь та нартай адилтгагдаж болно хэмээв. Мөн та нар Израилын угсааныхан учраас Исаиагаар яригдсан, та нартай адилтгагдаж болох олон зүйл буй бөлгөө.
  - 6 Мөн эдүгээ, тэрхүү үгс нь эдгээр болой: Их Эзэн Бурхан тийн хэлэв: Болгоогтун, би мутраа Харийнханд өргөнө, мөн далбаагаа хүмүүсийн тулд тогтоох болно; мөн тэд чиний хөвгүүдийг гар дээрээ авчирч, мөн чиний охид тэдний мөрөн дээр зөөгдөх болно.

## 2 Nephi 6

The words of Jacob, the brother of Nephi, which he spake unto the people of Nephi:

Behold, my beloved brethren, I, Jacob, having been called of God, and ordained after the manner of his holy order, and having been consecrated by my brother Nephi, unto whom ye look as a king or a protector, and on whom ye depend for safety, behold ye know that I have spoken unto you exceedingly many things.

Nevertheless, I speak unto you again; for I am desirous for the welfare of your souls. Yea, mine anxiety is great for you; and ye yourselves know that it ever has been. For I have exhorted you with all diligence; and I have taught you the words of my father; and I have spoken unto you concerning all things which are written, from the creation of the world.

And now, behold, I would speak unto you concerning things which are, and which are to come; wherefore, I will read you the words of Isaiah. And they are the words which my brother has desired that I should speak unto you. And I speak unto you for your sakes, that ye may learn and glorify the name of your God.

And now, the words which I shall read are they which Isaiah spake concerning all the house of Israel; wherefore, they may be likened unto you, for ye are of the house of Israel. And there are many things which have been spoken by Isaiah which may be likened unto you, because ye are of the house of Israel.

And now, these are the words: Thus saith the Lord God: Behold, I will lift up mine hand to the Gentiles, and set up my standard to the people; and they shall bring thy sons in their arms, and thy daughters shall be carried upon their shoulders.

- 7 Мөн хаад чиний асрагч эцгүүд мөн тэдний хатад чиний асрагч эхүүд байх болно; тэд чиний өмнө нүүрээ газарт хандуулан бөхийж, мөн чиний хөлийн тоосыг долоох болно; мөн би бол Их Эзэн гэдгийг чи мэдэх болно; учир нь намайг хүлээх тэд ичихгүй айх болно.
- 8 Мөн эдүгээ би, Иаков, эдгээр үгсийн талаар заримыг ярья. Учир нь болгоогтун, бидний орхиж явсан, Иерусалимд байсан тэд алагдаж мөн боолчлолд хүргэгдсэнийг Их Эзэн надад үзүүлсэн билээ.
- 9 Гэсэн хэдий ч, Их Эзэн тэдний буцаж ирэхийг надад үзүүлсэн. Мөн тэрээр түүнчлэн Их Эзэн Бурхан, Израилын Ариун Нэгэн тэдэнд өөрийгөө биеэр харуулахыг үзүүлсэн; мөн тэрээр өөрийгөө тэдэнд харуулсны дараа тэд түүнийг цээрлүүлэн мөн түүнийг цовдлох бөлгөө, надад хандан үүнийг ярьсан тэнгэр элчийн үгсийн дагуу буюу.
- 10 Мөн тэд Израилын Ариун Нэгэний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж мөн зөрүүдэлсний дараа, болгоогтун, Израилын Ариун Нэгэний шүүлтүүд тэдний дээр ирэх болно. Мөн тэд цохигдож мөн зовоогдох тэр өдөр ирэх буюу.
- 11 Иймийн тул, тэд нааш цааш туугдсаны дараа, тэнгэр элчийн тийн хэлсэнчлэн, олон нь маханбодиороо зовоогдсон байна, мөн итгэлтнүүдийн залбирлуудын учир, эрсдэх нь зөвшөөрөгдөхгүй байх болно; тэд тараагдаж, мөн цохигдож, мөн үзэн ядагдах болно, гэсэн хэдий ч, тэднийг Гэтэлгэгчийнхээ мэдлэгт ирэх цагт, тэд өвлөх нутгууддаа дахин нэгдэн цуглуулагдахын тулд Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй хандах болно.
- 12 Мөн бошиглогчийн бичиглэсэн тэдгээр харийнхан адислагдах болно; учир нь болгоогтун, хэрэв тэд наманчилж мөн Сионы эсрэг тэмцэхгүй бол, мөн өөрсдийгөө тэр агуу хийгээд жигшүүрт сүмд нэгтгэхгүй бол, тэд аврагдах болно; учир нь Их Эзэн Бурхан хүүхдүүдтэйгээ хийсэн гэрээнүүдээ тэрээр гүйцэлдүүлэх болно; мөн энэ шалтгааны учир мөнөөх бошиглогч эдгээр зүйлийг бичиглэсэн болой.

And kings shall be thy nursing fathers, and their queens thy nursing mothers; they shall bow down to thee with their faces towards the earth, and lick up the dust of thy feet; and thou shalt know that I am the Lord; for they shall not be ashamed that wait for me.

And now I, Jacob, would speak somewhat concerning these words. For behold, the Lord has shown me that those who were at Jerusalem, from whence we came, have been slain and carried away captive.

Nevertheless, the Lord has shown unto me that they should return again. And he also has shown unto me that the Lord God, the Holy One of Israel, should manifest himself unto them in the flesh; and after he should manifest himself they should scourge him and crucify him, according to the words of the angel who spake it unto me.

And after they have hardened their hearts and stiffened their necks against the Holy One of Israel, behold, the judgments of the Holy One of Israel shall come upon them. And the day cometh that they shall be smitten and afflicted.

Wherefore, after they are driven to and fro, for thus saith the angel, many shall be afflicted in the flesh, and shall not be suffered to perish, because of the prayers of the faithful; they shall be scattered, and smitten, and hated; nevertheless, the Lord will be merciful unto them, that when they shall come to the knowledge of their Redeemer, they shall be gathered together again to the lands of their inheritance.

And blessed are the Gentiles, they of whom the prophet has written; for behold, if it so be that they shall repent and fight not against Zion, and do not unite themselves to that great and abominable church, they shall be saved; for the Lord God will fulfil his covenants which he has made unto his children; and for this cause the prophet has written these things.



13 Иймийн тул, Сионы мөн Их Эзэний гэрээт хүмүүсийн эсрэг тэмцэх тэд тэдний хөлийн тоосыг долоох болно; мөн Их Эзэний хүмүүс ичгүүрлэгдэхгүй бөлгөө. Учир нь Их Эзэний хүмүүс бол түүнийг хүлээх тэд болой; учир нь тэд Мессиагийн ирэлтийг хүлээсээр л байх буюу.

14 Мөн болгоогтун, сайхь бошиглогчийн үгсийн дагуу, Мессиа дахин хоёр дахь удаагаа тэднийг буцааж авахаар өөрийгөө бэлтгэх болно; иймийн тул, тэд түүнд итгэх тэр өдрийг ирэхэд, тэрээр тэдэнд өөрийгөө хүчинд мөн агуу их алдар суунд, тэдний дайснуудын устгалд нотлон үзүүлэх болно; мөн түүнд итгэдэг нэгээхнийг ч тэрээр устгах нь үгүй.

15 Мөн түүнд үл итгэгч тэд галаар бас шуургаар аль алинаар нь, бас газар хөдлөлтөөр бас цус урсалтуудаар, бас өвчин тахлаар бас өлсгөлөнгөөр устгагдах болно. Мөн Их Эзэн бол Бурхан, Израилын Ариун Нэгэн гэдгийг тэд мэдэх болно.

16 Өөрөөр хэлбэл хүчтэнээс идэш нь булаагдаж, эсвээс хуулийн дагуу олзлогдсон нь чөлөөлөгдөх үү

17 Харин Их Эзэн хэлэв: Бүр чадалтай нэгний олзлогдосод булаагдах болно, мөн аймшигт нэгний идэш ч чөлөөлөгдөх болно; учир нь Хүчит Бурхан гэрээт хүмүүсээ чөлөөлөх болно. Учир нь Их Эзэнийн хэлэв: чамтай тэмцсэн тэдэнтэй би тэмцэх болно—

18 Мөн чамайг дарангуйлах тэднийг би өөрсдийнх нь махаар хооллох болно; мөн тэд өөрсдийнхөө цусанд, амтат дарсанд лугаа адил согтох болно; мөн би бол Их Эзэн чиний Аврагч мөн чиний Гэтэлгэгч, Иаковын Хүчит Нэгэн гэдгийг бүх маханбодь мэдэх болно.

Wherefore, they that fight against Zion and the covenant people of the Lord shall lick up the dust of their feet; and the people of the Lord shall not be ashamed. For the people of the Lord are they who wait for him; for they still wait for the coming of the Messiah.

And behold, according to the words of the prophet, the Messiah will set himself again the second time to recover them; wherefore, he will manifest himself unto them in power and great glory, unto the destruction of their enemies, when that day cometh when they shall believe in him; and none will he destroy that believe in him.

And they that believe not in him shall be destroyed, both by fire, and by tempest, and by earthquakes, and by bloodsheds, and by pestilence, and by famine. And they shall know that the Lord is God, the Holy One of Israel.

For shall the prey be taken from the mighty, or the lawful captive delivered?

But thus saith the Lord: Even the captives of the mighty shall be taken away, and the prey of the terrible shall be delivered; for the Mighty God shall deliver his covenant people. For thus saith the Lord: I will contend with them that contendeth with thee—

And I will feed them that oppress thee, with their own flesh; and they shall be drunken with their own blood as with sweet wine; and all flesh shall know that I the Lord am thy Savior and thy Redeemer, the Mighty One of Jacob.

## 2 Нифай 7

- 1 Тийм ээ, өөрөөр хэлбэл Их Эзэн тийн хэлэв Би чамайг холдуулж, эсвэл би чамайг үүрд зайлуулсан гэж уу? Тухайлбал Их Эзэн тийн хэлэв: Чиний эхийн гэрлэлт цуцлагдсан баримт хаана байна? Би чамайг хэнд зайлуулан өгч, эсвэл ямар зээлдүүлэгчиддээ би чамайг худалдсан билээ? Тийм ээ, хэнд би чамайг худалдсан билээ? Болгоогтун, алдсуудынхаа төлөөснөөс чи өөрийгөө худалдсан, мөн зөрчлүүдийн чинь учир эх чинь холдуулагдсан бөлгөө.
- 2 Иймийн тул, намайг ирэхэд хүн үгүй байв; намайг дуудахад, тийм ээ, хариулах хэн ч үгүй байв. Ай Израилын угсаа, аварч чадахааргүй болж гар минь өчүүхэн ч гэсэн богинодсон нь үгүй буюу, эсвээс надад чөлөөлөх хүч үгүй гэж үү? Болгоогтун, зэмлэлээрээ би далайг хатааж, би үүний ус, голыг аглаг газар болгон мөн ус нь хатсаны учир загас нь өмхийрч, мөн тэд цангасны учир үхэх болно.
- 3 Би тэнгэрт харыг өмсгөж, мөн би тэдний хучлагыг зотонгоор хийх бөлгөө.
- 4 Их Эзэн Бурхан эрдэмтний хэлийг надад өгсөн нь, би та нарт үгийг улиралд нь хэрхэн ярихыг мэдэхийн тулд билээ, Ай Израилын угсаа. Та нарыг эцэх үед тэрээр өглөөнөөс өглөөд сэрээх буюу. Эрдэмтэн мэт сонсохын тулд чихийг минь тэрээр сэрээх ажгуу.
- 5 Их Эзэн Бурхан чихийг минь нээсэн билээ, мөн би эсэргүүцсэн нь, мөн нүүр буруулсан нь ч үгүй.
- 6 Би нуруугаа занчигчдад, мөн хацраа үсийг нь зулгаах тэдэнд өгсөн билээ. Би нүүрээ ичгүүрээс мөн нулималтаас нуугаагүй.
- 7 Учир нь Их Эзэн Бурхан надад туслах болно, тиймийн тул би шившиглэгдэхгүй. Тиймийн тул би царайгаа цахиур чулуу лугаа адил болгосон буюу, мөн би ичгүүрлэгдэхгүй гэдгээ би мэддэг бөлгөө.
- 8 Мөн Их Эзэн ойрхон байна, мөн тэрээр намайг зөвтгөх болно. Хэн надтай тэрслэх билээ? Нэгдэн зогсоцгооё. Хэн миний өрсөлдөгч билээ? Тэр миний дэргэд ирэг, мөн би түүнийг үгийнхээ хүчээр цохих болно.
- 9 Учир нь Их Эзэн Бурхан надад туслах болно. Мөн намайг үгүйсгэх тэд бүгд, болгоогтун, тэд бүгд хувцас лугаа адил үжирч хуучран, мөн удган эрвээхий тэдгээрийг идэх болно.

## 2 Nephi 7

Yea, for thus saith the Lord: Have I put thee away, or have I cast thee off forever? For thus saith the Lord: Where is the bill of your mother's divorcement? To whom have I put thee away, or to which of my creditors have I sold you? Yea, to whom have I sold you? Behold, for your iniquities have ye sold yourselves, and for your transgressions is your mother put away.

Wherefore, when I came, there was no man; when I called, yea, there was none to answer. O house of Israel, is my hand shortened at all that it cannot redeem, or have I no power to deliver? Behold, at my rebuke I dry up the sea, I make their rivers a wilderness and their fish to stink because the waters are dried up, and they die because of thirst.

I clothe the heavens with blackness, and I make sackcloth their covering.

The Lord God hath given me the tongue of the learned, that I should know how to speak a word in season unto thee, O house of Israel. When ye are weary he waketh morning by morning. He waketh mine ear to hear as the learned.

The Lord God hath opened mine ear, and I was not rebellious, neither turned away back.

I gave my back to the smiter, and my cheeks to them that plucked off the hair. I hid not my face from shame and spitting.

For the Lord God will help me, therefore shall I not be confounded. Therefore have I set my face like a flint, and I know that I shall not be ashamed.

And the Lord is near, and he justifieth me. Who will contend with me? Let us stand together. Who is mine adversary? Let him come near me, and I will smite him with the strength of my mouth.

For the Lord God will help me. And all they who shall condemn me, behold, all they shall wax old as a garment, and the moth shall eat them up.

10 Та нарын дунд хэн чинь Их Эзэнээс эмээж, түүний үйлчлэгчийн дуу хоолойг дагаж, харанхуйд мөн гэрэл үгүй алхдаг вэ

11 Болгоогтун гал түлж өөрсдийгөө очоор хүрээлүүлсэн та нар бүгд, галынхаа гэрэлд мөн өөрт асаасныхаа очинд алхагтун. Та нар үүнийг миний гараас авах бөлгөө—та нар харамсан хэвтэх болно.

Who is among you that feareth the Lord, that obeyeth the voice of his servant, that walketh in darkness and hath no light?

Behold all ye that kindle fire, that compass yourselves about with sparks, walk in the light of your fire and in the sparks which ye have kindled. This shall ye have of mine hand—ye shall lie down in sorrow.

## 2 Нифай 8

- 1 Анхаарагтун намайг, зөв шударгын араас дагах та нар. Харагтун та нар өөрсдийн тэндээс бүтээгдсэн тэр хадыг, мөн та нарын ухагдаж гарсан тэр ормыг болой.
- 2 Харагтун өөрсдийн эцэг Абрахамыг, мөн та нарыг төрүүлсэн Сараг; өөрөөр хэлбэл би зөвхөн Абрахамыг дуудсан, мөн түүнийг адисалсан бөлгөө.
- 3 Өөрөөр хэлбэл Их Эзэн Сионыг тайтгаруулах болно, тэрээр түүний бүх эзгүй газруудыг тайтгаруулах болно; мөн тэрээр түүний аглаг буйдыг Еденийн адил, мөн түүний цөл газрыг Их Эзэний цэцэрлэг лугаа адил болгох болно. Баяр мөн баясал, талархал мөн аялгуут дуу тэндээс олодох болно.
- 4 Намайг анхаарагтун, хүмүүс минь; мөн чих тавин сонс, Ай миний үндэстэн; учир нь хууль надаас үүсэх болно, мөн хүмүүст гэрэл болохын тулд би өөрийн шүүлтийг тогтоох болно.
- 5 Миний зөв шударга байдал ойр; миний аврал тархсан, мөн миний мутар хүмүүсийг шүүх болно. Арлууд намайг найдан хүлээнэ, мөн тэд мутарт минь итгэх болно.
- 6 Харцаа тэнгэрт хандуулагтун, мөн доош газрыг харагтун; тэгээд тэнгэр нь утаа мэт замхран, мөн газар хувцас лугаа адил үжрэх болно; мөн түүнд орших тэд дээрхийн адил үжэх болно. Харин миний аврал үүрд байх болно, мөн миний зөв шударга байдал үгүйсгэгдэхгүй байх болно.
- 7 Намайг анхаарагтун, зөв шударгыг та нар мэднэ, би хуулиа зүрх сэтгэлд нь бичсэн хүмүүс та нар, хүмүүний зэмлэлээс бүү эмээгтүн, бас тэдний доромжлолуудаас битгий ай.
- 8 Учир нь удган эрвээхий тэднийг хувцас лугаа адил идэж орхих болно, мөн тэднийг өт ноос лугаа адил идэх болно. Харин миний зөв шударга байдал үүрд, мөн миний аврал үеэс үед байх болно.
- 9 Сэр, сэрэгтүн! Хүчээ авагтун, Ай Их Эзэний мутар; эртний өдрүүдийн адил сэр. Рахабыг хэрчиж, мөн лууг шархдуулсан тэр нь та бус уу
- 10 Ёроолгүй гүн усыг мөн далайг хатаасан; далайн гүнийг суллагдасдад гатлах зам болгосон тэр нь та бус уу

## 2 Nephi 8

Hearken unto me, ye that follow after righteousness. Look unto the rock from whence ye are hewn, and to the hole of the pit from whence ye are digged.

Look unto Abraham, your father, and unto Sarah, she that bare you; for I called him alone, and blessed him.

For the Lord shall comfort Zion, he will comfort all her waste places; and he will make her wilderness like Eden, and her desert like the garden of the Lord. Joy and gladness shall be found therein, thanksgiving and the voice of melody.

Hearken unto me, my people; and give ear unto me, O my nation; for a law shall proceed from me, and I will make my judgment to rest for a light for the people.

My righteousness is near; my salvation is gone forth, and mine arm shall judge the people. The isles shall wait upon me, and on mine arm shall they trust.

Lift up your eyes to the heavens, and look upon the earth beneath; for the heavens shall vanish away like smoke, and the earth shall wax old like a garment; and they that dwell therein shall die in like manner. But my salvation shall be forever, and my righteousness shall not be abolished.

Hearken unto me, ye that know righteousness, the people in whose heart I have written my law, fear ye not the reproach of men, neither be ye afraid of their revilings.

For the moth shall eat them up like a garment, and the worm shall eat them like wool. But my righteousness shall be forever, and my salvation from generation to generation.

Awake, awake! Put on strength, O arm of the Lord; awake as in the ancient days. Art thou not he that hath cut Rahab, and wounded the dragon?

Art thou not he who hath dried the sea, the waters of the great deep; that hath made the depths of the sea a way for the ransomed to pass over?

11 Тиймийн тул, Их Эзэнээр гэтэлгэгдэгсэд эргэж ирнэ, мөн Сионд дуулсаар орох болно; мөн үүрдийн баясал мөн ариун байдал тэдний тэргүүн дээр байх болно; мөн тэд баяр мөн баяслыг олж авах болно; харуусал хийгээд гашуудал зайлан одох болно.

12 Би бол тэрбээр; тийм ээ, би бол та нарыг тайтгаруулагч тэрбээр. Болгоогтун, үхэх тэр хүнээс мөн өвс лугаа адил болгогдох тэр хүний хүүгээс эмээх чи хэн билээ

13 Мөн устгахад бэлэн байсан мэт дарлагчийн уур омгийн учир, өдөр бүр үргэлж айж, мөн тэнгэрийг асарлан мөн газрын суурийг тавьсан чамайг бүтээгч Их Эзэнийг мартаж хэн билээ? Мөнхүү дарлагчийн уур омог хаана байна

14 Боолчлолд цөлөгдсөн нь тэрээр суллагдаж болхын тулд, мөн тэрээр нүхэнд үхэхгүй байхын тулд, мөн тэрээр талхнаасаа салах вий хэмээх учир яаран сандрах бөлгөө.

15 Харин би бол давалгаа нь хүрхэрсэн Их Эзэн чиний Бурхан, Түмний Их Эзэн гэдэг нь миний нэр болой.

16 Мөн би үгсээ аманд чинь хийж, мөн мутрын сүүдрээрээ чамайг халхалсан, би тэнгэрийг шигтгэж мөн газрын суурийг тавихын тулд мөн Сионд: Болгоогтун, та нар бол миний хүмүүс гэдгийг хэлэхийн тулд болой.

17 Сэр, сэр, бос, Ай Иерусалим, Их Эзэний мутарт байх түүний хилэгнэлийн аяганаас уусан тэр—чи салгалуулах аягыг шавхан шаарыг нь ч мушгин уусан буюу—

18 Мөн Иерусалимын төрүүлсэн бүх хөвгүүдийн дунд түүнийг удирдах нэгээхэн ч алга; мөн түүний өсгөсөн бүх хөвгүүдээс түүний гараас хөтлөх хэн ч байсангүй.

19 Чиний хоосрол мөн устгал, мөн өлсгөлөн болон илд—чиний төлөө харамсах энэ хоёр хөвгүүн чамд ирнэ—мөн хэнээр би чамайг тайтгаруулах билээ

20 Чиний хөвгүүд шантарсан, энэ хоёроос бусад нь; тэд гудамж бүрийн эхэнд хэвтэнэ; тэд урхинд орсон зэрлэг бух лугаа адил Бурханы тань зэмлэл болон Их Эзэний хилэнгээр дүүрэн байна.

Therefore, the redeemed of the Lord shall return, and come with singing unto Zion; and everlasting joy and holiness shall be upon their heads; and they shall obtain gladness and joy; sorrow and mourning shall flee away.

I am he; yea, I am he that comforteth you. Behold, who art thou, that thou shouldst be afraid of man, who shall die, and of the son of man, who shall be made like unto grass?

And forgettest the Lord thy maker, that hath stretched forth the heavens, and laid the foundations of the earth, and hast feared continually every day, because of the fury of the oppressor, as if he were ready to destroy? And where is the fury of the oppressor?

The captive exile hasteneth, that he may be loosed, and that he should not die in the pit, nor that his bread should fail.

But I am the Lord thy God, whose waves roared; the Lord of Hosts is my name.

And I have put my words in thy mouth, and have covered thee in the shadow of mine hand, that I may plant the heavens and lay the foundations of the earth, and say unto Zion: Behold, thou art my people.

Awake, awake, stand up, O Jerusalem, which hast drunk at the hand of the Lord the cup of his fury— thou hast drunken the dregs of the cup of trembling wrung out—

And none to guide her among all the sons she hath brought forth; neither that taketh her by the hand, of all the sons she hath brought up.

These two sons are come unto thee, who shall be sorry for thee—thy desolation and destruction, and the famine and the sword—and by whom shall I comfort thee?

Thy sons have fainted, save these two; they lie at the head of all the streets; as a wild bull in a net, they are full of the fury of the Lord, the rebuke of thy God.

- 21 Тиймийн тул эдүгээ үүнийг сонс, зовсон, мөн согтсон та нар, харин дарсанд бус:
- 22 Их Эзэн тань тийн хэлж байна, Их Эзэн мөн чиний Бурхан өөрийн хүмүүсийн төлөө өмгөөлөх ажгуу; болгоогтун, би салгалуулах аягыг чиний гараас авсан, миний хилэнгийн аяганы шаарыг буюу; чи үүнээс хойш үүнийг дахин уухгүй байх болно.
- 23 Харин би чамайг зовоогч тэдний гарт үүнийг тавих болно; чиний бодгальд: Доош бөхий, бид дээгүүр чинь явж болохын тулд хэмээн хэлсэн тэдэнд буюу—мөн чи өөрийн биеийг дээгүүр тань явсан тэдэнд газар мөн гудамж мэт дэвссэн буюу.
- 24 Сэр, сэр, хүчээ авагтун, Ай Сион; гоёмсог өмсгөлөө өмс, Ай Иерусалим, ариун хот; учир нь үүнээс хойш хөвч хөндүүлээгүй болон цэвэр бус нь чамд орохгүй.
- 25 Шороо тоосоо сэгсэр; босоод суу, Ай Иерусалим; хүзүүн дэх хүлээснээсээ өөрийгөө сулла, Ай Сионы боолчлогдогч охин.

Therefore hear now this, thou afflicted, and drunken, and not with wine:

Thus saith thy Lord, the Lord and thy God pleadeth the cause of his people; behold, I have taken out of thine hand the cup of trembling, the dregs of the cup of my fury; thou shalt no more drink it again.

But I will put it into the hand of them that afflict thee; who have said to thy soul: Bow down, that we may go over—and thou hast laid thy body as the ground and as the street to them that went over.

Awake, awake, put on thy strength, O Zion; put on thy beautiful garments, O Jerusalem, the holy city; for henceforth there shall no more come into thee the uncircumcised and the unclean.

Shake thyself from the dust; arise, sit down, O Jerusalem; loose thyself from the bands of thy neck, O captive daughter of Zion.

## 2 Нифай 9

- 1 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нар бүх Израилын угсаатай Их Эзэн гэрээлсэн түүний гэрээнүүдийн талаар мэдэж болох буюу хэмээн би эдгээр зүйлсийг уншлаа—
- 2 Тэрээр иудейчүүдэд, өөрийн ариун бошиглогчдын амаар ярьсан зүйлийн талаар—бүр эхлэлээс хойш, үеэс үед, тэд Бурханы үнэн сүмд мөн сүрэгт сэргээгдэх тэр цагийг хүртэл; тэд өөрсдийн өвлөж авсан нутгууд болох гэртээ цуглуулагдах болно, мөн бүх амлалтын нутгууддаа төвхнүүлэгдэх тэр цагт буюу.
- 3 Болгоогтун, хайрт ах дүү нар минь, Их Эзэн Бурхан хүүхдүүд дээр тань цутгах адислалуудын учир тэргүүнээ ямагт дээр өргөж мөн та нар баясаж болно хэмээн би та нарт эдгээр зүйлсийг ярьж байна.
- 4 Та нарын олон тань ирэх зүйлүүдийн талаар мэдэхийн тулд, ихийг судалсныг би мэднэ; иймийн тул маханбодь маань элэгдэж мөн үхэх ёстойг та нар мэддэгийг би мэднэ; гэсэн хэдий ч, өөрсдийнхөө биед Бурханыг бид харах болно.
- 5 Тийм ээ, бидний тэндээс ирсэн Иерусалимд тэдэнд тэрээр өөрийгөө биеэр үзүүлэхийг та нар мэднэ гэдгийг би мэднэ; энэ нь тэдний дунд байх нь зайлшгүйн учир болой; бүх хүмүүн түүний харьяалалд байж болохын тулд, агуу их Бүтээгч өөрийгөө маханбодиор хүмүүний харьяалалд байлгаж, бүх хүмүүний төлөө нас юүлэхийг хүлцэх нь шаардагдсан учир бөлгөө.
- 6 Агуу их Бүтээгчийн нигүүлсэнгүй төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн тулд үхэл бүх хүмүүний дээр улиран ирсэнчлэн амилуулалтын хүч байх ёстой болж, мөн амилуулалт нь хүмүүнд уналтаас шалтгаалан ирэх ёстой нь зайлшгүй; мөн уналт нь зөрчлөөс шалтгаалан ирсэн буюу; мөн хүмүүн уналтанд орсон учир тэд Их Эзэний дэргэдээс зайлуулагдсан билээ.

## 2 Nephi 9

And now, my beloved brethren, I have read these things that ye might know concerning the covenants of the Lord that he has covenanted with all the house of Israel—

That he has spoken unto the Jews, by the mouth of his holy prophets, even from the beginning down, from generation to generation, until the time comes that they shall be restored to the true church and fold of God; when they shall be gathered home to the lands of their inheritance, and shall be established in all their lands of promise.

Behold, my beloved brethren, I speak unto you these things that ye may rejoice, and lift up your heads forever, because of the blessings which the Lord God shall bestow upon your children.

For I know that ye have searched much, many of you, to know of things to come; wherefore I know that ye know that our flesh must waste away and die; nevertheless, in our bodies we shall see God.

Yea, I know that ye know that in the body he shall show himself unto those at Jerusalem, from whence we came; for it is expedient that it should be among them; for it behooveth the great Creator that he suffereth himself to become subject unto man in the flesh, and die for all men, that all men might become subject unto him.

For as death hath passed upon all men, to fulfil the merciful plan of the great Creator, there must needs be a power of resurrection, and the resurrection must needs come unto man by reason of the fall; and the fall came by reason of transgression; and because man became fallen they were cut off from the presence of the Lord.

7 Иймийн тул, хязгааргүй цагаатгал байх нь зайлшгүй—цагаатгал хязгааргүй байхаас бусдаар бол энэ биеийн ялзрал муудашгүй болж чадахгүй. Иймийн тул, хүмүүний дээр ирсэн эхний шүүлт төгсгөлгүйгээр үлдэх ёстой байсан бөлгөө. Мөн хэрэв тийм аваас, энэ маханбодь дахин хэзээ ч босохгүйгээр ялзран хэвтэж мөн үүний эх болох газарт үйрэх ёстой байсан буюу.

8 Ай Бурханы мэргэн ухаан, түүний нигүүлсэл мөн ач гавьяа! Учир нь болгоогтун, хэрэв маханбодь дахин хэзээ ч босохгүй аваас Мөнхийн Бурханы дэргэдээс дахин хэзээ ч босохгүйгээр унаж тэгээд чөтгөр болсон тэрхүү тэнгэр элчийн харьяалалд бидний сүнс орох ёстой болой.

9 Мөн бидний сүнснүүд түүнтэй адил болж, мөн бид чөтгөрүүд, чөтгөрийн элчүүд болж, Бурханыхаа дэргэдээс таслагдаж, мөн худал бүхний эцэгтэй хамт, өөртэй нь адилаар зовлонд үлдэх байсан; тийм ээ, бидний анхны эцэг эхийг мэхэлсэн тэр, өөрийгөө гэрлийн тэнгэр элч мэт болгон хувиргаж мөн аллагын нууц хуйвалдаанд болон бүх төрлийн харанхуй дахь нууц хэргүүдэд хүмүүний үрсийг өдөөн хатгадаг тэр болой.

10 Энэхүү аймшигт мангасын атганаас зугтах бидний замыг бэлтгэх, Ай Бурханы маань сайн сайхан хичнээн агуу билээ; тийм ээ, тэр мангас, үхэл болон там, биеийн үхэл мөн түүнчлэн сүнсний үхэл гэж миний нэрлэх тэр буюу.

11 Мөн бидний Бурхан Израилын Ариун Нэгэний чөлөөлөх замын учир, энэ үхэл, миний ярьсан, зуурдынх болох тэр нь үүнд буй үхэгсдийгээ чөлөөлөх болно; мөнхүү үхэл нь булш болой.

12 Мөн миний ярьсан сүнсний үхэл болох энэхүү үхэл үхэгсдээ чөлөөлөх болно; мөнхүү сүнсний үхэл нь там болой; иймийн тул, үхэл болон там нь үхэгсдээ чөлөөлнө, мөн там нь олзлогдсон сүнснүүдээ чөлөөлөх ёстой, мөн булш нь олзлогдсон биесээ чөлөөлөх ёстой, мөн хүмүүний бие хийгээд сүнснүүд нэг нэгэндээ дахин нэгдэх болно; мөн энэ нь Израилын Ариун Нэгэний амилуулалтын хүчээр байх буюу.

Wherefore, it must needs be an infinite atonement—save it should be an infinite atonement this corruption could not put on incorruption. Wherefore, the first judgment which came upon man must needs have remained to an endless duration. And if so, this flesh must have laid down to rot and to crumble to its mother earth, to rise no more.

O the wisdom of God, his mercy and grace! For behold, if the flesh should rise no more our spirits must become subject to that angel who fell from before the presence of the Eternal God, and became the devil, to rise no more.

And our spirits must have become like unto him, and we become devils, angels to a devil, to be shut out from the presence of our God, and to remain with the father of lies, in misery, like unto himself; yea, to that being who beguiled our first parents, who transformeth himself nigh unto an angel of light, and stirreth up the children of men unto secret combinations of murder and all manner of secret works of darkness.

O how great the goodness of our God, who prepareth a way for our escape from the grasp of this awful monster; yea, that monster, death and hell, which I call the death of the body, and also the death of the spirit.

And because of the way of deliverance of our God, the Holy One of Israel, this death, of which I have spoken, which is the temporal, shall deliver up its dead; which death is the grave.

And this death of which I have spoken, which is the spiritual death, shall deliver up its dead; which spiritual death is hell; wherefore, death and hell must deliver up their dead, and hell must deliver up its captive spirits, and the grave must deliver up its captive bodies, and the bodies and the spirits of men will be restored one to the other; and it is by the power of the resurrection of the Holy One of Israel.



13 Ай Бурханы маань төлөвлөгөө хичнээн агуу билээ! Учир нь нөгөө талаас нь харвал Бурханы диваажин зөв шударгыг үйлдэгчдийн сүнснүүдийг чөлөөлнө, мөн булш зөв шударгыг үйлдэгчдийн биеийг чөлөөлөх ёстой; мөн сүнс болон бие нь өөртөө дахин нэгдэнэ, мөн бүх хүмүүн муудахгүй, мөн үхэшгүй болж, мөн тэд амьд бодгаль байж, бидэнд махан бодид байгаагийн адил төгс мэдлэгтэй байна, бидний мэдлэг төгс байхаас бусдаар буюу.

14 Иймийн тул, бид өөрсдийн бүх гэм, өөрсдийн бохирын, мөн өөрсдийн нүцгэн байдлын төгс мэдлэгтэй байх болно; мөн зөв шударгыг үйлдэгсэд өөрсдийн жаргал, мөн өөрсдийн зөв шударга үйлүүдийн төгс мэдлэгтэй байх болно, цэврээр хувцасласан байсны, тийм ээ, бүр зөв шударгын орхимжтой байсны учир болой.

15 Мөнхүү улиран тохиох дор бүх хүмүүн, тэд үхэшгүй болох учраас, энэ эхний үхлээсээ амьдралд шилжих болно, тэд Израилын Ариун Нэгэний шүүлтийн суудлын өмнө очих ёстой; мөн тэгээд шүүлт ирнэ, мөн тийнхүү Бурханы ариун шүүлтийн дагуу тэд шүүгдэх ёстой.

16 Мөн зөв шударга тэд зөв шударгаараа байх болно, харин бузар булай тэд бузар булайгаараа л байх болно; иймийн тул, бузар булай тэд чөтгөр мөн түүний элчүүд байдаг; мөн тэд өөрсдөд нь энд зориулан бэлтгэгдсэн үүрдийн түймэрт очих болно; мөн тэдний зовлон, дөл нь үүрд болон үргэлж мөн төгсгөлгүйгээр дүрэлзэх галт болон хүхэрт нуур лугаа адил болой; мөн энэ нь гарцаагүй Их Эзэн амьдын адил, өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан үүнийг ярьсан, мөн энэ нь улирч одох нь үгүй түүний мөнхийн үг болой.

17 Ай Бурханы маань сүр хүчин хийгээд шударга ёс! Учир нь тэрээр өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлнэ, мөн тэдгээр нь түүний амнаас гарсан юм, мөн түүний хууль биелэгдэх ёстой.

18 Гэвч, болгоогтун, зөв шударгыг үйлдэгсэд, Израилын Ариун Нэгэний гэгээнтнүүд, Израилын Ариун Нэгэнд итгэсэн тэд, дэлхийн загалмайнүүдыг тэвчиж мөн ичгүүрийг умартсан тэд дэлхийн сууринаас тэдэнд бэлтгэгдсэн тэрхүү Бурханы хаант улсыг өвлөх ажгуу, мөн тэдний баяр үүрд бялхаж байх болно.

O how great the plan of our God! For on the other hand, the paradise of God must deliver up the spirits of the righteous, and the grave deliver up the body of the righteous; and the spirit and the body is restored to itself again, and all men become incorruptible, and immortal, and they are living souls, having a perfect knowledge like unto us in the flesh, save it be that our knowledge shall be perfect.

Wherefore, we shall have a perfect knowledge of all our guilt, and our uncleanness, and our nakedness; and the righteous shall have a perfect knowledge of their enjoyment, and their righteousness, being clothed with purity, yea, even with the robe of righteousness.

And it shall come to pass that when all men shall have passed from this first death unto life, insomuch as they have become immortal, they must appear before the judgment-seat of the Holy One of Israel; and then cometh the judgment, and then must they be judged according to the holy judgment of God.

And assuredly, as the Lord liveth, for the Lord God hath spoken it, and it is his eternal word, which cannot pass away, that they who are righteous shall be righteous still, and they who are filthy shall be filthy still; wherefore, they who are filthy are the devil and his angels; and they shall go away into everlasting fire, prepared for them; and their torment is as a lake of fire and brimstone, whose flame ascendeth up forever and ever and has no end.

O the greatness and the justice of our God! For he executeth all his words, and they have gone forth out of his mouth, and his law must be fulfilled.

But, behold, the righteous, the saints of the Holy One of Israel, they who have believed in the Holy One of Israel, they who have endured the crosses of the world, and despised the shame of it, they shall inherit the kingdom of God, which was prepared for them from the foundation of the world, and their joy shall be full forever.

19 Ай Израилын Ариун Нэгэн, Бурханы маань нигүүлслийн сүр хүчин! Учир нь тэрээр өөрийн гэгээнтнүүдийг аймшигт мангас болох чөтгөр мөн үхэл, мөн там, мөн төгсгөлгүй зовлон болох тэр галт болон хүхэрт нуураас чөлөөлөх бөлгөө.

20 Ай Бурханы маань ариун чанар хичнээн агуу их билээ! Учир нь тэрээр бүх зүйлийг мэддэг, мөн түүний мэдлэгээс гадуур нэгээхэн ч зүйл эс орших буюу.

21 Мөн хэрэв тэд түүний дууг анхааран сонсвоос бүх хүмүүнийг аварч болохын тулд тэрээр дэлхийд ирнэ; учир нь болгоогтун, тэрээр бүх хүмүүний шаналлыг тэвчинэ, тийм ээ, амьдрагч бүхний шаналлыг, Адамын гэр бүлд багтах эр, эм, мөн хүүхэд аль алиныхыг нь болой.

22 Бүх хүмүүний дээр амилуулалт тохиож болохын тулд мөн агуу их хийгээд шүүлтийн өдөр бүгд түүний өмнө зогсож болохын тулд, тэрээр үүнийг тэвчих бөлгөө.

23 Мөн тэд Израилын Ариун Нэгэнд төгс итгэлтэйгээр наманчилж, мөн түүний нэрээр баптисм хүртэж ёстойг тэрээр бүх хүмүүнд зарлигласан билээ, эс бөгөөс тэд Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй.

24 Мөн хэрэв тэд наманчилж мөн түүний нэрэнд итгэж, мөн түүний нэрээр баптисм хүртэж, мөн эцсээ хүртэл тэвчихгүй аваас, тэд яллагдах ёстой; учир нь Их Эзэн Бурхан, Израилын Ариун Нэгэн үүнийг ярьсан бөлгөө.

25 Иймийн тул, тэрээр хууль өгсөн буюу; мөн хууль өгөгдөөгүй тэнд шийтгэл үгүй байна; мөн шийтгэл үгүй тэнд ял үгүй бөлгөө; мөн ял үгүй тэнд Израилын Ариун Нэгэний нигүүлслүүд тэдний дээр цагаатгалын учир орших ажгуу; учир нь тэд түүний хүчээр чөлөөлөгдсөн бөлгөө.

26 Тухайлбал хууль өгөгдөөгүй тэдэнд, бүгдийнх нь дээр түүний шударга ёсны шаардлагыг цагаатгал хангах учир, тэд аймшигт мангас болно, үхэл мөн там, мөн чөтгөр, мөн төгсгөлгүй зовлон болох тэрхүү галт болон хүхэрт нуураас чөлөөлөгдөх болой; мөн тэдэнд амьсгал өгсөн, Израилын Ариун Нэгэн болох тэрхүү Бурханд тэд сэргээгдэх болно.

O the greatness of the mercy of our God, the Holy One of Israel! For he delivereth his saints from that awful monster the devil, and death, and hell, and that lake of fire and brimstone, which is endless torment.

O how great the holiness of our God! For he knoweth all things, and there is not anything save he knows it.

And he cometh into the world that he may save all men if they will hearken unto his voice; for behold, he suffereth the pains of all men, yea, the pains of every living creature, both men, women, and children, who belong to the family of Adam.

And he suffereth this that the resurrection might pass upon all men, that all might stand before him at the great and judgment day.

And he commandeth all men that they must repent, and be baptized in his name, having perfect faith in the Holy One of Israel, or they cannot be saved in the kingdom of God.

And if they will not repent and believe in his name, and be baptized in his name, and endure to the end, they must be damned; for the Lord God, the Holy One of Israel, has spoken it.

Wherefore, he has given a law; and where there is no law given there is no punishment; and where there is no punishment there is no condemnation; and where there is no condemnation the mercies of the Holy One of Israel have claim upon them, because of the atonement; for they are delivered by the power of him.

For the atonement satisfieth the demands of his justice upon all those who have not the law given to them, that they are delivered from that awful monster, death and hell, and the devil, and the lake of fire and brimstone, which is endless torment; and they are restored to that God who gave them breath, which is the Holy One of Israel.

27 Гэвч бидэнд байгаагийн адил хууль, тийм ээ, Бурханы бүх зарлигууд өгөгдсөн, мөн тэдгээрийг зөрчсөн, мөн сорилтын өдрүүдээ дэмий үрсэн түүнд халаг, учир нь түүний байдал аймшигтай байх болно.

28 Ай тэр хилэнцэт нэгний зальт төлөвлөгөө! Ай хүмүүний бардам зан, мөн эмзэглэл, мөн мунхаглал! Тэд аливааг сураад өөрсдийгөө ухаантай хэмээн санадаг, мөн тэд Бурханы зөвлөмжийг эс анхаардаг, учир нь тэд үл ойшоож, тэд өөрсдөө мэднэ гэж боддог, иймийн тул, тэдний мэргэн ухаан нь тэнэглэл байж мөн энэ нь тэдэнд ашгийг эс өгнө. Мөн тэд мөхөх болно.

29 Гэвч хэрэв тэд Бурханы зөвлөмжийг анхааран сонсох аваас суралцсан байх нь сайн хэрэг.

30 Харин энэ дэлхийн зүйлүүдээр баян болох тэрхүү баянд халаг. Тухайлбал тэд баян учраас ядууг гадуурхдаг, мөн тэд номхон дөлгөөн хүмүүсийг хавчиж, мөн тэдний зүрх сэтгэл хөрөнгөн дээрээ байдаг; иймийн тул, тэдний хөрөнгө нь тэдний бурхан. Мөн болгоогтун, тэдний хөрөнгө нь тэдэнтэй хамт түүнчлэн мөхөх болно.

31 Мөн сонсохыг үл хүсэх дүлийд халаг; учир нь тэд мөхөх болно.

32 Харахыг үл хүсэх сохорт халаг; учир нь тэд түүнчлэн мөхөх болно.

33 Зүрх сэтгэл нь хөндөгдөөгүй тэдэнд халаг, учир нь тэдний алдсуудын мэдлэг тэднийг эцсийн өдөр цохих болно.

34 Худалчид халаг, учир нь тэрээр доош тамд хөөгдөх болно.

35 Санаатайгаар егүүтгэх алуурчинд халаг, учир нь тэрээр үхэх болно.

36 Садар самууныг үйлдэгч тэдэнд халаг, учир нь тэд доош тамд хөөгдөх болно.

37 Тийм ээ, хиймэл шүтээнийг бишрэгч тэдэнд халаг, учир нь бүх чөтгөрүүдийн чөтгөр тэдэнд баясах бөлгөө.

38 Мөн, эцэст нь, нүглүүддээ үхэх тэдэнд халаг; учир нь тэд Бурханд эргэж очин, мөн түүний царайг болгоож, мөн нүглүүддээ үлдэх болно.

But wo unto him that has the law given, yea, that has all the commandments of God, like unto us, and that transgresseth them, and that wasteth the days of his probation, for awful is his state!

O that cunning plan of the evil one! O the vainness, and the frailties, and the foolishness of men! When they are learned they think they are wise, and they hearken not unto the counsel of God, for they set it aside, supposing they know of themselves, wherefore, their wisdom is foolishness and it profiteth them not. And they shall perish.

But to be learned is good if they hearken unto the counsels of God.

But wo unto the rich, who are rich as to the things of the world. For because they are rich they despise the poor, and they persecute the meek, and their hearts are upon their treasures; wherefore, their treasure is their god. And behold, their treasure shall perish with them also.

And wo unto the deaf that will not hear; for they shall perish.

Wo unto the blind that will not see; for they shall perish also.

Wo unto the uncircumcised of heart, for a knowledge of their iniquities shall smite them at the last day.

Wo unto the liar, for he shall be thrust down to hell.

Wo unto the murderer who deliberately killeth, for he shall die.

Wo unto them who commit whoredoms, for they shall be thrust down to hell.

Yea, wo unto those that worship idols, for the devil of all devils delighteth in them.

And, in fine, wo unto all those who die in their sins; for they shall return to God, and behold his face, and remain in their sins.

39 Ай, хайрт ах дүү нар минь, Ариун Бурханы эсрэг зөрчилдөх нь аймшигтайг, мөн түүнчлэн башир нэгний уруу тагалтуудад бууж өгөх нь аймшигтайг сана. Биеэ бодох нь үхэл, мөн сүнсээ бодох нь мөнх амьдрал гэдгийг сана.

40 Ай, хайрт ах дүү нар минь, миний үгсэд чих тавьцгаа. Израилын Ариун Нэгэний сүр жавхланг сана. Би та нарын эсрэг хатуу зүйлүүдийг ярьсан гэж битгий хэл; учир нь хэрэв та нар тэгвэл үнэнийг эсэргүүцэн доромжилсон болно; өөрөөр хэлбэл та нарыг Бий Боллогчийн үгсийг би ярьсан болой. Бүхий л цэвэр бусын эсрэг үнэн үгс хатууг би мэднэ; харин зөв шударгыг үйлдэгчид тэдгээрээс эмээхгүй, учир нь тэд үнэнд дуртай мөн гуйвуулагдах нь үгүй.

41 Ай тэгээд, хайрт ах дүү нар минь, Ариун Нэгэн, Их Эзэнд ирцгээ. Түүний замууд зөв шударгыг сана. Болгоогтун, хүмүүнд зориулагдсан харгуй нарийн, гэвч энэ нь түүний өмнө шулуунаар зурайна, мөн Израилын Ариун Нэгэн бол их хаалганы сахиул; мөн тэрээр нэгээхэн зарцыг тэнд үл ажиллуулдаг; мөн уг хаалганаас өөр зам гэж үгүй; учир нь тэрээр мэхлэгдэх боломжгүй, түүний нэр Их Эзэн Бурхан билээ.

42 Мөн хэн тогшнов, түүнд тэрээр нээх болно; мөн ухаантай, мөн суралцсан, бас баян тэд, өөрсдийн боловсрол, мөн цэцэн ухаан, мөн баялгийнхаа учир ихэрхдэг—тийм ээ, тэд бол түүний гадуурхах тэд болой; тэд эдгээр зүйлүүдээ хаяж, мөн Бурханы өмнө өөрсдийн мунхгийг мэдэж, мөн даруу байдлын гүнд доошлон ирэхээс бусдаар бол, тэрээр тэдэнд нээхгүй байх болно.

43 Гэвч ухаантай мөн сэрэмжтэй хүний зүйлүүд тэднээс үүрд далдлагдах болно—тийм ээ, гэгээнтнүүдэд бэлтгэгдсэн тэр аз жаргал болой.

44 Ай, хайрт ах дүү нар минь, миний үгсийг сана. Болгоогтун, би өмсгөлүүдээ тайлж, мөн би тэдгэрийг та нарын өмнө сэгсэрье; би авралын Бурхандаа тэрээр намайг бүхнийг халиах мэлмийгээрээ тольдоосой хэмээн залбирья; иймийн тул, бүх хүмүүн үйлүүдээрээ шүүгдэх тэр эцсийн өдөр би та нарын алдсуудыг өөрийн бодгалиас сэгсэрснийг, мөн би түүний өмнө туяаран зогсохыг, мөн та нарын цуснаас ангижирсныг Израилын Бурхан гэрчилснийг та нар мэдэх болно.

O, my beloved brethren, remember the awfulness in transgressing against that Holy God, and also the awfulness of yielding to the enticings of that cunning one. Remember, to be carnally-minded is death, and to be spiritually-minded is life eternal.

O, my beloved brethren, give ear to my words. Remember the greatness of the Holy One of Israel. Do not say that I have spoken hard things against you; for if ye do, ye will revile against the truth; for I have spoken the words of your Maker. I know that the words of truth are hard against all uncleanness; but the righteous fear them not, for they love the truth and are not shaken.

O then, my beloved brethren, come unto the Lord, the Holy One. Remember that his paths are righteous. Behold, the way for man is narrow, but it lieth in a straight course before him, and the keeper of the gate is the Holy One of Israel; and he employeth no servant there; and there is none other way save it be by the gate; for he cannot be deceived, for the Lord God is his name.

And whoso knocketh, to him will he open; and the wise, and the learned, and they that are rich, who are puffed up because of their learning, and their wisdom, and their riches—yea, they are they whom he despiseth; and save they shall cast these things away, and consider themselves fools before God, and come down in the depths of humility, he will not open unto them.

But the things of the wise and the prudent shall be hid from them forever—yea, that happiness which is prepared for the saints.

O, my beloved brethren, remember my words. Behold, I take off my garments, and I shake them before you; I pray the God of my salvation that he view me with his all-searching eye; wherefore, ye shall know at the last day, when all men shall be judged of their works, that the God of Israel did witness that I shook your iniquities from my soul, and that I stand with brightness before him, and am rid of your blood.

45 Ай, хайрт ах дүү нар минь, нүглүүдээсээ салцгаа; та нарыг бөх гэгч нь хүлэх хүсэлтэй түүний гинжийг сэгсрэн хая; авралын тань хад болох Бурханд ирцгээ.

46 Шударга ёс, зөв шударгыг үйлдэгчдэд хүртээгдэнэ, та нар аймшигт айдсаасаа болж навтайхгүй байж болохын тулд, та нар аймшигт гэмээ төгс санахгүй байж болохын тулд; мөн өөрийн эрхгүй дуу алдаж: Ариун, таны шүүлтүүд ариун юм, Ай Их Эзэн Бүхнийг Чадагч Бурхан— гэвч би гэмээ мэднэ; би таны хуулийг зөрчсөн, мөн миний зөрчлүүд бол минийх; мөн чөтгөр намайг эзэмшиж, би түүний аймшигт зовлонгийн олз болжээ хэмээхгүй байж болохын тулд та нар өөрсдийн бодгалиудыг бүр шүүлтийн өдөр болох тэр дуурсгалт өдөрт бэлтгэцгээ.

47 Гэвч болгоогтун, ах дүү нар минь, эдгээр зүйлүүдийн аймшигт бодит байдалд та нарыг би сэрээх ёстой болж байгаа нь зүйд нийцнэ гэж үү? Хэрэв та нарын санаа бодол цэвэр байсан аваас би бодгалиудыг тань тарчилгана гэж үү? Хэрэв та нар нүглээс ангижирсан аваас үнэний тодорхой байдлын дагуу би та нарт тодорхойгоор ярих гэж үү

48 Болгоогтун, хэрэв та нар ариун байсан аваас би та нарт ариун чанарын тухай ярихсан; гэвч та нар ариун бус учир, мөн та нар багшийгаа хэмээн надад хандах учир, би та нарт нүглийн уршгуудыг сургах нь зайлшгүй байх ёстой зохист зүйл ажгуу.

49 Болгоогтун, бодгаль минь нүглийг жигшиж, харин зүрх сэтгэл минь зөв шударгад баясдаг; мөн би Бурханыхаа ариун нэрийг магтан дуулах болно.

50 Ирцгээ, ах дүү нар минь, цангасан бүхэн, та нар усанд ирцгээ; мөн мөнгөгүй тэр нь, ирээд худалдаж ав мөн ид; тийм ээ, ирээд дарс болон сүүг мөнгөгүйгээр мөн үнэгүйгээр худалдаж ав.

51 Иймийн тулд, үнэт биш зүйлд мөнгө, бас хэрэгцээг чинь хангаж чадахгүй зүйлд хөдөлмөрөө бүү үр. Намайг хичээнгүйлэн сонс, мөн миний ярьсан эдгээр үгсийг сана; мөн Израилын Ариун Нэгэнд ир, мөн мөхөх нь үгүй тэр, бас ялзрах нь үгүй түүний дээр найрла, мөн бодгаль чинь шимт болгонд баясаг.

52 Болгоогтун, хайрт ах дүү нар минь, Бурханыхаа үгсийг сана; түүнд өдрөөр байнга залбирч бай, мөн шөнөөр түүний ариун нэрэнд талархал мэдүүл. Зүрх сэтгэл чинь баярлаг.

O, my beloved brethren, turn away from your sins; shake off the chains of him that would bind you fast; come unto that God who is the rock of your salvation.

Prepare your souls for that glorious day when justice shall be administered unto the righteous, even the day of judgment, that ye may not shrink with awful fear; that ye may not remember your awful guilt in perfectness, and be constrained to exclaim: Holy, holy are thy judgments, O Lord God Almighty—but I know my guilt; I transgressed thy law, and my transgressions are mine; and the devil hath obtained me, that I am a prey to his awful misery.

But behold, my brethren, is it expedient that I should awake you to an awful reality of these things? Would I harrow up your souls if your minds were pure? Would I be plain unto you according to the plainness of the truth if ye were freed from sin?

Behold, if ye were holy I would speak unto you of holiness; but as ye are not holy, and ye look upon me as a teacher, it must needs be expedient that I teach you the consequences of sin.

Behold, my soul abhorreth sin, and my heart delighteth in righteousness; and I will praise the holy name of my God.

Come, my brethren, every one that thirsteth, come ye to the waters; and he that hath no money, come buy and eat; yea, come buy wine and milk without money and without price.

Wherefore, do not spend money for that which is of no worth, nor your labor for that which cannot satisfy. Harken diligently unto me, and remember the words which I have spoken; and come unto the Holy One of Israel, and feast upon that which perisheth not, neither can be corrupted, and let your soul delight in fatness.

Behold, my beloved brethren, remember the words of your God; pray unto him continually by day, and give thanks unto his holy name by night. Let your hearts rejoice.

53 Мөн болгоогтун Их Эзэний гэрээнүүд хичнээн агуу их, мөн хүмүүний үрс дэх хүлцлүүд хичнээн агуу билээ; мөн түүний сүр жавхлан, мөн түүний ач ивээл болон нигүүлслийн учир, бидний үр удам бие махбодийн дагуу бүрмөсөн устгагдахгүй, харин тэрээр тэднийг хадгалан хамгаалах болно хэмээн бидэнд амласан билээ; мөн ирээдүйн үеийнхэнд тэд Израилын угсаанд нэгэн зөв шударга мөчир байх болно.

54 Мөн эдүгээ, ах дүү нар минь, би та нарт илүүг ярихсан; гэвч маргааш би та нарт үгсийнхээ үлдсэнийг тунхаглах болно. Амен.

And behold how great the covenants of the Lord, and how great his condescensions unto the children of men; and because of his greatness, and his grace and mercy, he has promised unto us that our seed shall not utterly be destroyed, according to the flesh, but that he would preserve them; and in future generations they shall become a righteous branch unto the house of Israel.

And now, my brethren, I would speak unto you more; but on the morrow I will declare unto you the remainder of my words. Amen.

## 2 Нифай 10

- 1 Мөн эдүгээ би, Иаков, та нарт дахин ярья, хайрт ах дүү нар минь, миний ярьсан зөв шударга мөчрийн талаар буюу.
- 2 Учир нь болгоогтун, бидний хүртсэн амлалтууд бидэнд маханбодид байхын дагуу амлалтууд юм; иймийн тул, бидний хүүхдүүдээс олон нь итгэлгүйн учир бие махбодиороо мөхнө, гэсэн хэдий ч, Бурхан олны дээр нигүүлсэнгүй байх болно гэдэг нь надад үзүүлэгдсэн билээ; мөн тэдний Гэтэлгэгчийн үнэн мэдлэгийг тэдэнд өгөх түүнд ирж болохын тулд бидний хүүхдүүд сэргээгдэх болно.
- 3 Иймийн тул, би та нарт хэлсэнчлэн, Христ—учир нь өнгөрсөн шөнө тэнгэр элч надад энэ нь түүний нэр байхыг ярилаа—Иудейчүүдийн дунд зайлшгүй ирэх ёстой, дэлхийн илүү ёсон бус хэсэг болох тэдний дунд болой; мөн тэд түүнийг цовдолно—өөрөөр хэлбэл тэрчлэн энэ нь бидний Бурханы зүгээс шаардагдах, мөн өөрсдийн Бурханыг цовдлох өөр ямар ч үндэстэн энэ дэлхий дээр үгүй.
- 4 Учир нь бусад үндэстнүүдийн дунд агуу гайхамшгууд бүтээгдсэн бол тэд наманчилж, мөн тэр бол өөрсдийнх нь Бурхан гэдгийг мэдэх бөлгөө.
- 5 Гэвч санваараар мэргэших явдал мөн алдсуудын учир, Иерусалим дахь тэд түүний эсрэг зөрүүдлэх болно, тэгснээр тэр цовдлогдох болно.
- 6 Иймийн тул, тэдний алдсуудын учир, устгалууд, өлсгөлөнгүүд, тахлууд, мөн үсчих цус тэдний дээр ирэх болно; мөн устгагдахгүй тэд бүх үндэстний дунд тараагдах болно.
- 7 Гэвч болгоогтун, Их Эзэн Бурхан ийн хэлэв: Би бол Христ хэмээн надад итгэх тэр өдөр ирэхэд, тэр үед би тэдний эцэг өвгөдтэй тэд газар дэлхий дээр, өөрсдийн өв болох нутгуудад, бие махбодийн дагуу сэргээгдэх болно хэмээн гэрээлсэн болой.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн удаан хугацааны тараагдалтаасаа, далайн арлуудаас, мөн газар дэлхийн дөрвөн зүгээс цуглуулагдах болно; мөн тэднийг өвийн нутгуудад нь аваачихын хувьд харийнханы үндэстнүүд мэлмийд минь агуу байх болно хэмээн Бурхан хэлсэн болой.

## 2 Nephi 10

And now I, Jacob, speak unto you again, my beloved brethren, concerning this righteous branch of which I have spoken.

For behold, the promises which we have obtained are promises unto us according to the flesh; wherefore, as it has been shown unto me that many of our children shall perish in the flesh because of unbelief, nevertheless, God will be merciful unto many; and our children shall be restored, that they may come to that which will give them the true knowledge of their Redeemer.

Wherefore, as I said unto you, it must needs be expedient that Christ—for in the last night the angel spake unto me that this should be his name—should come among the Jews, among those who are the more wicked part of the world; and they shall crucify him—for thus it behooveth our God, and there is none other nation on earth that would crucify their God.

For should the mighty miracles be wrought among other nations they would repent, and know that he be their God.

But because of priestcrafts and iniquities, they at Jerusalem will stiffen their necks against him, that he be crucified.

Wherefore, because of their iniquities, destructions, famines, pestilences, and bloodshed shall come upon them; and they who shall not be destroyed shall be scattered among all nations.

But behold, thus saith the Lord God: When the day cometh that they shall believe in me, that I am Christ, then have I covenanted with their fathers that they shall be restored in the flesh, upon the earth, unto the lands of their inheritance.

And it shall come to pass that they shall be gathered in from their long dispersion, from the isles of the sea, and from the four parts of the earth; and the nations of the Gentiles shall be great in the eyes of me, saith God, in carrying them forth to the lands of their inheritance.

9 Тийм ээ, харийнханы хаад тэдэнд асрагч эцгүүд байх болно, мөн тэдний хатад асрагч эхчүүд нь болох болно; иймийн тул, харийнханд зориулсан Их Эзэний амлалтууд агуу их, учир нь тэрээр үүнийг ярьсан болой, мөн хэн маргаж чадах билээ

10 Гэвч болгоогтун, энэ нутаг, та нарын өвийн нутаг байх болно, мөн харийнхан уг нутаг дээр адислагдах болно хэмээн Бурхан хэлжээ.

11 Мөн энэ нутаг нь харийнханд эрх чөлөөний нутаг байх болно, мөн уг нутаг дээр харийнханд тодруулагдах хаад гэж үгүй байх болно.

12 Мөн би энэ нутгийг бусад бүх үндэстний эсрэг бэхлэх болно.

13 Мөн Сионы эсрэг тулалдах тэр нь мөхөх болно хэмээн Бурхан хэлэх ажгуу.

14 Учир нь миний эсрэг хааныг тодруулах тэр мөхөх болно, учир нь бибээр, Их Эзэн, тэнгэрийн хаан, тэдний хаан байх болно, мөн үгсийг минь анхааран сонсох тэдэнд би үүрд гэрэл байх болно.

15 Иймийн тул тэднийг бие маханбодид байхад нь тэдэнд үйлдэх тэрхүү, хүмүүний үрсэд миний хийсэн миний гэрээнүүд гүйцэлдэж болох энэ шалтгааны учир, би харанхуйн, мөн аллагуудын, мөн жигшүүрт хэргүүдийн нуугдмал үйлүүдийг устгах нь зайлшгүй байх ёстой.

16 Иймийн тул, Сионы эсрэг тулалдах тэрээр, Иудей ч мөн Харь ч бай, хоригдол ч мөн чөлөөт хүн ч бай, эр эм алин боловч мөхөх болно; өөрөөр хэлбэл тэд бүх дэлхийн садар эм бөлгөө; учир нь миний төлөө бус тэд бол миний эсрэг байдаг хэмээн бидний Бурхан хэлдэг.

17 Учир нь би тэдэнд бие маханбодид байхад нь үйлдэх болно хэмээн би хүмүүний үрсэд өгсөн тэр амлалтуудаа гүйцэлдүүлэх болно—

18 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, бидний Бурхан ийн хэлсэн билээ: Би чиний үр удмыг харийнханы гараар зовоох болно; гэсэн хэдий ч, тэдэнд тэд эцгийн адил байхын тулд би харийнханы зүрх сэтгэлийг зөөллөх болно; иймийн тул, уг харийнхан Израилын угсааныхны дунд тоологдож мөн адислагдах болно.

Yea, the kings of the Gentiles shall be nursing fathers unto them, and their queens shall become nursing mothers; wherefore, the promises of the Lord are great unto the Gentiles, for he hath spoken it, and who can dispute?

But behold, this land, said God, shall be a land of thine inheritance, and the Gentiles shall be blessed upon the land.

And this land shall be a land of liberty unto the Gentiles, and there shall be no kings upon the land, who shall raise up unto the Gentiles.

And I will fortify this land against all other nations.

And he that fighteth against Zion shall perish, saith God.

For he that raiseth up a king against me shall perish, for I, the Lord, the king of heaven, will be their king, and I will be a light unto them forever, that hear my words.

Wherefore, for this cause, that my covenants may be fulfilled which I have made unto the children of men, that I will do unto them while they are in the flesh, I must needs destroy the secret works of darkness, and of murders, and of abominations.

Wherefore, he that fighteth against Zion, both Jew and Gentile, both bond and free, both male and female, shall perish; for they are they who are the whore of all the earth; for they who are not for me are against me, saith our God.

For I will fulfil my promises which I have made unto the children of men, that I will do unto them while they are in the flesh—

Wherefore, my beloved brethren, thus saith our God: I will afflict thy seed by the hand of the Gentiles; nevertheless, I will soften the hearts of the Gentiles, that they shall be like unto a father to them; wherefore, the Gentiles shall be blessed and numbered among the house of Israel.



- 19 Иймийн тул, би энэ нутгийг чиний удамд, мөн чиний удмын дунд тоологдох тэдэнд, үүрд, тэдний өвлөсөн нутаг байлгахаар ариулан адислах болно; Бурхан надад хэлснээр, тухайлбал энэ нь сонгомол нутаг билээ, бусад бүх нутгаас дээгүүр буюу, иймийн тул түүний дээр орших бүх хүмүүн намайг шүтэхийг би шаардах болно хэмээн Бурхан хэлэх ажгуу.
- 20 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, бидний нигүүлсэнгүй Бурхан бидэнд эдгээр зүйлүүдийн талаар ийм агуу мэдлэг өгсний учир, түүнийг санацгаая, мөн нүглүүдээ холдуулж, мөн тэргүүнээ огтхон ч үл гудайлгацгаая, учир нь бид зайлуулагдаагүй билээ; бид өвлөсөн нутгаасаа гаргагдсан хэдий ч, гэвч бид илүү сайхан нутаг тийш удирдагдсан, учир нь Их Эзэн далайг бидний харгуй болгосон бөгөөд бид далайн арал дээр байх бөлгөө.
- 21 Харин Их Эзэний амлалтууд далайн арлууд дээрх тэдэнд агуу их билээ; иймийн тул үүнд арлууд хэмээн хэлсний учир, үүнээс гадна байх нь зайлшгүй, мөн түүнчлэн тэдгээр нь бидний ах дүү нараар эзэмшигдэх болно.
- 22 Учир нь болгоогтун, Их Эзэн Бурхан Израилын угсаанаас цагаас цагт, өөрийн дур мөн тааллын дагуу гадагш удирдсан буюу. Мөн эдүгээ болгоогтун, Их Эзэн салгагдах тэд бүгдийг санах болно, иймийн тул тэрээр түүнчлэн биднийг ч санах бөлгөө.
- 23 Тиймийн тул, зүрх сэтгэлээ урамтай болгоцгоо, мөн та нар өөрсдөдөө үйлдэх эрх чөлөөтэй гэдгээ сана—үүрдийн үхлийн зам, эс бөгөөс мөнх амьдралын замыг сонгох тэр ажгуу.
- 24 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, Бурханы таалалд өөрсдийгөө эвлэрүүл, харин чөтгөрийн болон биеийн таалалд бус; мөн та нар Бурханд эвлэрүүлэгдсэнийхээ дараа, та нар аврагдана, энэ нь зөвхөн Бурханы ач ивээлд мөн үүний дагуу байна гэдгийг санагтун.
- 25 Иймийн тул, та нар бурханлиг ач ивээлийн дагуу түүнийг магтан дуулж болохын тулд, та нар мөнхийн Бурханы хаант улсад хүлээн зөвшөөрөгдөж болохын тулд, Бурхан та нарыг үхлээс амилуулалтын хүчээр, мөн түүнчлэн цагаатгалын хүчээр үүрдийн үхлээс босгох болтугай. Амен.

Wherefore, I will consecrate this land unto thy seed, and them who shall be numbered among thy seed, forever, for the land of their inheritance; for it is a choice land, saith God unto me, above all other lands, wherefore I will have all men that dwell thereon that they shall worship me, saith God.

And now, my beloved brethren, seeing that our merciful God has given us so great knowledge concerning these things, let us remember him, and lay aside our sins, and not hang down our heads, for we are not cast off; nevertheless, we have been driven out of the land of our inheritance; but we have been led to a better land, for the Lord has made the sea our path, and we are upon an isle of the sea.

But great are the promises of the Lord unto them who are upon the isles of the sea; wherefore as it says isles, there must needs be more than this, and they are inhabited also by our brethren.

For behold, the Lord God has led away from time to time from the house of Israel, according to his will and pleasure. And now behold, the Lord remembereth all them who have been broken off, wherefore he remembereth us also.

Therefore, cheer up your hearts, and remember that ye are free to act for yourselves—to choose the way of everlasting death or the way of eternal life.

Wherefore, my beloved brethren, reconcile yourselves to the will of God, and not to the will of the devil and the flesh; and remember, after ye are reconciled unto God, that it is only in and through the grace of God that ye are saved.

Wherefore, may God raise you from death by the power of the resurrection, and also from everlasting death by the power of the atonement, that ye may be received into the eternal kingdom of God, that ye may praise him through grace divine. Amen.

## 2 Нифай 11

- 1 Мөн эдүгээ, Иаков тэр цагт илүү олон зүйлийг миний хүмүүст ярив; гэсэн хэдий ч зөвхөн эдгээр зүйлийг би бичүүлэв, өөрөөр хэлбэл миний бичиглэсэн тэдгээр зүйлүүд нь миний хувьд хангалттай.
- 2 Мөн эдүгээ би, Нифай, Исаиагийн үгсээс дахиад заримыг нь бичье, учир нь бодгаль минь түүний үгсэд баясах бөлгөө. Өөрөөр хэлбэл би түүний үгсийг өөрийн хүмүүстэй адилтгана, мөн би тэдгээрийг өөрийн бүх хүүхдүүдэд улируулан илгээх болно, учир нь тэрээр миний Гэтэлгэгчийг үнэхээр харсан, бүр би түүнийг харсны адил болой.
- 3 Мөн би түүнийг харсны адилаар миний дүү, Иаков, түүнчлэн түүнийг харсан билээ; иймийн тул, би үгс маань үнэн гэдгийг нотлохын тулд тэдний үгсийг хүүхдүүддээ илгээх болно. Иймийн тул, гурвын үгсээр, Бурхан хэлж, би өөрийн үгийг тогтоох болно гэжээ. Гэсэн хэдий ч, Бурхан илүү олон гэрчийг илгээх болно, мөн өөрийн бүх үгсийг тэрбээр нотлох ажгуу.
- 4 Болгоогтун, Христийн ирэлтийн үнэнийг өөрийн хүмүүст нотлохдоо бодгаль минь баяснам; учир нь энэ зорилгын тулд Мосегийн хууль өгөгдсөн болой; мөн хүмүүнд, энэ дэлхийн эхлэлээс Бурханаас өгөгдөх тэдгээр бүх зүйл, түүнийг бэлэгдэх ажгуу.
- 5 Мөн түүнчлэн бидний өвөг дээдэстэй Их Эзэний хийсэн түүний гэрээнд бодгаль минь баяснам; тийм ээ, үхлээс чөлөөлөх түүний агуу хийгээд мөнхийн төлөвлөгөөн дэх ач ивээл, мөн түүний шударга ёс, мөн хүч, мөн нигүүлсэлд бодгаль минь баяснам.
- 6 Мөн Христ ирнэ, үгүй бол бүх хүмүүн мөхөх ёстойг өөрийн хүмүүст нотлохдоо бодгаль минь баяснам.
- 7 Учир нь хэрэв Христ үгүй бол Бурхан гэж үгүй; мөн хэрэв Бурхан үгүй аваас бид эс оршино, бүтээлт байж үл болохын учир бөлгөө. Гэвч Бурхан буй, мөн тэр бол Христ, мөн тэрээр өөрийн цаг хугацааны бүрэн байдалд ирэх болно.

## 2 Nephi 11

And now, Jacob spake many more things to my people at that time; nevertheless only these things have I caused to be written, for the things which I have written sufficient me.

And now I, Nephi, write more of the words of Isaiah, for my soul delighteth in his words. For I will liken his words unto my people, and I will send them forth unto all my children, for he verily saw my Redeemer, even as I have seen him.

And my brother, Jacob, also has seen him as I have seen him; wherefore, I will send their words forth unto my children to prove unto them that my words are true. Wherefore, by the words of three, God hath said, I will establish my word. Nevertheless, God sendeth more witnesses, and he proveth all his words.

Behold, my soul delighteth in proving unto my people the truth of the coming of Christ; for, for this end hath the law of Moses been given; and all things which have been given of God from the beginning of the world, unto man, are the typifying of him.

And also my soul delighteth in the covenants of the Lord which he hath made to our fathers; yea, my soul delighteth in his grace, and in his justice, and power, and mercy in the great and eternal plan of deliverance from death.

And my soul delighteth in proving unto my people that save Christ should come all men must perish.

For if there be no Christ there be no God; and if there be no God we are not, for there could have been no creation. But there is a God, and he is Christ, and he cometh in the fulness of his own time.

8 Мөн эдүгээ миний хүмүүсээс эдгээр үгсийг уншсан хэн боловч тэдний зүрх сэтгэл хөөрч мөн бүх хүмүүний төлөө баясаж болохын тулд, би Исаиагийн зарим үгсийг бичих болно. Эдүгээ эдгээр нь тэрхүү үгс, мөн та нар тэдгээрийг өөрсөдтэйгөө мөн бүх хүмүүнтэй адилтгаж болох ажгуу.

And now I write some of the words of Isaiah, that whoso of my people shall see these words may lift up their hearts and rejoice for all men. Now these are the words, and ye may liken them unto you and unto all men.

## 2 Нифай 12

- 1 Иудей болон Иерусалимын талаар үзсэн, Амозын хүү Исаиагийн үг:
- 2 Мөнхүү улиран тохиох дор эцсийн өдрүүдэд, Их Эзэний өргөөний уул нь уулсын оргил дээр баригдаж, мөн толгодын дээр өргөгдөхөд бүх үндэстнүүд үүнд цутган ирэх болно.
- 3 Мөн олон хүмүүс явж мөн хэлэх болно, Ирэгтүн та нар, мөн Их Эзэний уул өөд, Иаковын Бурханы өргөөнд очигцоо; мөн тэрээр бидэнд өөрийн замуудын талаар сургах болно, мөн бид түүний харгуйгаар алхах болно; өөрөөр хэлбэл Сионоос хууль, мөн Их Эзэний үг Иерусалимаас ундрэн гарах болой.
- 4 Мөн тэрээр үндэстнүүдийн дунд шүүж, мөн олон хүмүүнийг зэмлэх болно: мөн тэд илдээ анжисны хошуу болгон, мөн жаднуудаа хасуур болгон давтах болно—үндэстэн үндэстнийхээ эсрэг илд далайхгүй, бас тэд дайнд дахин хэзээ ч суралцахгүй байх болно.
- 5 Ай Иаковын угсаа, та нар ирэгтүн мөн Их Эзэний гэрэлд алхацгаая; тийм ээ, ирэгтүн, учир нь та нар бүгд төөрч одсон, хүн бүр өөрийн ёсон бус замуудад буюу.
- 6 Тиймийн тул, Ай Их Эзэн, та өөрийн хүмүүсийг, Иаковын угсааг орхисон, учир юун хэмээвээс тэд филистинчүүдийн адил зөгнөн хэлэгчдийн үгэнд орж, мөн тэд өөрсдийгөө гадныхны хүүхдүүдэд таацуулсан, дорнын нөлөөгөөр дүүргэгдсэн болой.
- 7 Тэдний нутаг түүнчлэн мөнгө болон алтаар дүүрэн, бас тэдний эрдэнийн сан төгсгөлгүй; тэдний нутаг түүнчлэн морьдоор дүүрэн, бас тэдний их тэрэгний нь тоо төгсгөлгүй билээ.
- 8 Тэдний нутаг түүнчлэн хиймэл шүтээнүүдээр дүүрэн; тэд өөрсдийн хуруугаар үйлдсэн тэдгээрийг, өөрсдийн гарын бүтээлээ тэд шүтдэг.
- 9 Мөн ерийн хүн толгой үл бөхийж, мөн их хүн өөрийгөө үл даруусгадаг, тиймийн тул, түүнийг бүү өршөө.

## 2 Nephi 12

The word that Isaiah, the son of Amoz, saw concerning Judah and Jerusalem:

And it shall come to pass in the last days, when the mountain of the Lord's house shall be established in the top of the mountains, and shall be exalted above the hills, and all nations shall flow unto it.

And many people shall go and say, Come ye, and let us go up to the mountain of the Lord, to the house of the God of Jacob; and he will teach us of his ways, and we will walk in his paths; for out of Zion shall go forth the law, and the word of the Lord from Jerusalem.

And he shall judge among the nations, and shall rebuke many people: and they shall beat their swords into plow-shares, and their spears into pruning-hooks—nation shall not lift up sword against nation, neither shall they learn war any more.

O house of Jacob, come ye and let us walk in the light of the Lord; yea, come, for ye have all gone astray, every one to his wicked ways.

Therefore, O Lord, thou hast forsaken thy people, the house of Jacob, because they be replenished from the east, and hearken unto soothsayers like the Philistines, and they please themselves in the children of strangers.

Their land also is full of silver and gold, neither is there any end of their treasures; their land is also full of horses, neither is there any end of their chariots.

Their land is also full of idols; they worship the work of their own hands, that which their own fingers have made.

And the mean man boweth not down, and the great man humbleth himself not, therefore, forgive him not.

10 Ай ёс бусыг үйлдэгчид та нар, Их Эзэнээс айх айдас мөн түүний сүр хүчний алдар суу та нарыг цохих учир хад чулуунд орогтун мөн өөрсдийгөө шороонд нуу.

11 Мөнхүү улиран тохиох дор хүмүүний ихэмсэг төрх даруусгагдан, мөн хүмүүний ихэрхэг байдал доош гудайлгагдах болно, мөн тэр өдөр Их Эзэн ганцаараа өргөмжлөгдөх болно.

12 Учир нь Түмний Их Эзэний өдөр удахгүй бүх үндэстнүүдийн дээр ирнэ, тийм ээ, тэд бүгдийн дээр; бардам болон ихэмсгийн дээр, мөн хөөргөн болгоны дээр, мөн тэрээр дорд үзэгдэх буюу.

13 Тийм ээ, мөн Их Эзэний өдөр Ливаны бүх хуш моднууд дээр ирэх болно, тэдгээр нь өндөр мөн хөөрсний учир болой, мөн Башаны бүх царснууд дээр буюу;

14 Мөн бүхий л өндөр уулсын дээр, мөн бүх толгодын дээр, мөн хөөргөгдсөн тэдгээр бүх үндэстнүүдийн дээр, мөн ард түмэн бүрийн дээр;

15 Мөн өндөр цамхаг бүрийн дээр, мөн хашлагат хана бүрийн дээр;

16 Мөн далайн бүхий л онгоцнуудын дээр, мөн Таршишийн бүх хөлөг онгоцнууд дээр, мөн бүх тааламжтай сайхан дүрслэлүүд дээр буюу.

17 Мөн хүмүүний ихэмсэглэл доош гудайлгагдаж, мөн хүмүүний ихэрхэг байдал дорд үзэгдэх болно; мөн тэр өдөр Их Эзэн ганцаар өргөмжлөгдөх болно.

18 Мөн хиймэл шүтээнүүдийг тэрээр бүрмөсөн үгүй хийх болно.

19 Мөн тэд хадны хонгилд, мөн газрын агуйд хоргодох болно, тэрээр газар дэлхийг аймшигтайгаар сэгсрэхээр босоход Их Эзэнээс айх айдас тэдний дээр ирнэ, мөн түүний сүр жавхлангийн их нь тэднийг цохихын учир болой.

20 Тэр өдөр хүмүүн өөрийн мөнгөн шүтээнийг, мөн өөрийн алтан шүтээнийг, тэрээр шүтэхийн тулд өөртөө хийсэн тэдгээрийг, сохор номин болон сарьсан багваахайд хаях болно.

21 Хадны нөмөрт, мөн барзгар хадны оройд очно, учир нь тэрээр газар дэлхийг аймшигтайгаар сэгсрэхээр босоход Их Эзэнээс айх айдас тэдний дээр ирнэ, түүний сүр жавхлангийн их нь тэднийг цохихын учир болой.

O ye wicked ones, enter into the rock, and hide thee in the dust, for the fear of the Lord and the glory of his majesty shall smite thee.

And it shall come to pass that the lofty looks of man shall be humbled, and the haughtiness of men shall be bowed down, and the Lord alone shall be exalted in that day.

For the day of the Lord of Hosts soon cometh upon all nations, yea, upon every one; yea, upon the proud and lofty, and upon every one who is lifted up, and he shall be brought low.

Yea, and the day of the Lord shall come upon all the cedars of Lebanon, for they are high and lifted up; and upon all the oaks of Bashan;

And upon all the high mountains, and upon all the hills, and upon all the nations which are lifted up, and upon every people;

And upon every high tower, and upon every fenced wall;

And upon all the ships of the sea, and upon all the ships of Tarshish, and upon all pleasant pictures.

And the loftiness of man shall be bowed down, and the haughtiness of men shall be made low; and the Lord alone shall be exalted in that day.

And the idols he shall utterly abolish.

And they shall go into the holes of the rocks, and into the caves of the earth, for the fear of the Lord shall come upon them and the glory of his majesty shall smite them, when he ariseth to shake terribly the earth.

In that day a man shall cast his idols of silver, and his idols of gold, which he hath made for himself to worship, to the moles and to the bats;

To go into the clefts of the rocks, and into the tops of the ragged rocks, for the fear of the Lord shall come upon them and the majesty of his glory shall smite them, when he ariseth to shake terribly the earth.

22 Та нар хамрынхаа нүхэнд амьсгалах тэр, хүмүүнд  
хандахаа боль, түүнийг юуны учир хүндэтгэнэ вэ

Cease ye from man, whose breath is in his nostrils;  
for wherein is he to be accounted of?

## 2 Нифай 13

- 1 Учир нь болгоогтун, Их Эзэн, Түмний Их Эзэн, зайлуулан авах болой, Иерусалимаас, мөн Иудейгаас, түших тулгуурыг мөн таягийг, талх болох бүтэн таягийг нь ч, мөн ус болох бүтэн тулгуурыг ч буюу—
- 2 Чадалтай хүнийг, мөн дайнч хүнийг, шүүгч, мөн бошиглогч, мөн хашир сэрэмжтэй нэгнийг, мөн ахмад нэгнийг;
- 3 Тавийн ахмад, мөн хүндэт нэгэн, мөн зөвлөх, мөн уран дархан, мөн уран илтгэгчийг.
- 4 Мөн би хүүхдүүдийг тэдний ханхүү байхаар тэнд өгөх болно, мөн нялхас тэдний дээр захирах болно.
- 5 Мөн хүмүүс нэг нь нөгөөгөөрөө, мөн хүн бүр хөршүүдээрээ дарамтлуулах болно; хүүхэд өөрийгөө ахмад нэгний эсрэг дээгүүрт тавин бардамнах буюу, мөн адгийн муу нь хүндэт нэгний эсрэг болой.
- 6 Хүн эцгийнхээ отгийнх болох ахдаа хэлэх нь: Танд хувцас буй, та бидний захирагч бол, мөн таны мутрын дор энэхүү устгал мөхөл бүү халдаг—
- 7 Тэр өдөр тэрээр тангараглаж, хэлэх нь: би эдгээгч байх нь үгүй; учир нь миний гэрт талх ч, хувцас ч алга; хүмүүсийн захирагч бүү болго намайг.
- 8 Учир нь Иерусалим балгас болсон, мөн Иудей унасан болой, тэдний хэл ам, хийсэн үйлүүд Их Эзэний эсрэг байсан нь, түүний сүр жавхлант мэлмийг өдөөн уурлуулсны учир бөлгөө.
- 9 Тэдний төрх байдал тэдний эсрэг гэрчилж, мөн тэдний нүгэл бүр Содомын адил болохыг тунхагласан ажгуу, мөн тэд үүнийгээ далдалж чадахгүй. Тэдний бодгалиудад халаг, тэд хилэнцийг өөрсөддөө шагнал болгосны учир болой.
- 10 Тэдэнд сайн болохыг зөв шударгыг үйлдэгчдэд хэл; учир нь тэд үйлүүдийнхээ үр жимсийг хүртэх болно.
- 11 Ёс бусыг үйлдэгчдэд халаг, учир нь тэд мөхөх болно; тэдний гарын шагнал тэдний дээр байх болно!

## 2 Nephi 13

For behold, the Lord, the Lord of Hosts, doth take away from Jerusalem, and from Judah, the stay and the staff, the whole staff of bread, and the whole stay of water—

The mighty man, and the man of war, the judge, and the prophet, and the prudent, and the ancient;

The captain of fifty, and the honorable man, and the counselor, and the cunning artificer, and the eloquent orator.

And I will give children unto them to be their princes, and babes shall rule over them.

And the people shall be oppressed, every one by another, and every one by his neighbor; the child shall behave himself proudly against the ancient, and the base against the honorable.

When a man shall take hold of his brother of the house of his father, and shall say: Thou hast clothing, be thou our ruler, and let not this ruin come under thy hand—

In that day shall he swear, saying: I will not be a healer; for in my house there is neither bread nor clothing; make me not a ruler of the people.

For Jerusalem is ruined, and Judah is fallen, because their tongues and their doings have been against the Lord, to provoke the eyes of his glory.

The show of their countenance doth witness against them, and doth declare their sin to be even as Sodom, and they cannot hide it. Wo unto their souls, for they have rewarded evil unto themselves!

Say unto the righteous that it is well with them; for they shall eat the fruit of their doings.

Wo unto the wicked, for they shall perish; for the reward of their hands shall be upon them!

12 Мөн миний хүмүүсийг, хүүхдүүд тэдний дарлагчид байж, эмэгтэйчүүд тэднийг захиран удирдах болно. Ай хүмүүс минь, та нарыг удирдаж буй тэд та нарыг буруут болгосон мөн та нарын замнах замыг устгадаг бөлгөө.

13 Их Эзэн өмгөөлөхөөр босно, мөн хүмүүсийг шүүхээр босох болно.

14 Их Эзэн өөрийн хүмүүсийн эртнийхэн мөн тэдний хан хөвгүүдтэй шүүхэд заалдах болно; учир нь та нар ядуугийн талбайг мөн ядуугийн хөрөнгийг өөрсдийнхөө гэрт идэж дуусгасан билээ.

15 Та нар ямар учиртай билээ? Та нар миний хүмүүсийг тасчдаг, мөн ядуугийн нүүрийг няцалдаг хэмээн Түмний Их Эзэн Бурхан хэлэх буюу.

16 Үүнээс гадна, Их Эзэн хэлдэг: Сионы охид ихэмсэг, мөн хүзүү сунган завхай харц чулуудан алхалж, явахдаа сайварлан, мөн хөлөн дэх хонхоо жингэнүүлэн алхдаг—

17 Тиймийн тул Их Эзэн Сионы охидын зулайг яр шарханд бариулж мөн Их Эзэн тэдний нууц хэсгүүдийг нь ил харуулах болно.

18 Тэр өдөр Их Эзэн тэдний хангинан жингэнэх чимгүүдийн мөн үсний тор, мөн сар адил дугираг гархинуудын тансаг үзэмжийг нь булаан авах болно;

19 Шаргих гинжнүүд мөн бугуйвчнууд, мөн хүзүүний ороолтуудын;

20 Товь малгайнууд, мөн хөлийн чимгүүд, мөн толгойн алчуурууд, мөн пайзнууд, мөн ээмэгнүүдийн;

21 Бөгжнүүд, мөн хамрын гоёлуудын;

22 Сольж өмсөх хувцасны зүйл, мөн нөмрөг, мөн толгойн бүрх, мөн үсний хатгууруудын;

23 Шил толинууд, мөн нарийн нэхээст эд, мөн юүдэн, мөн гивлүүрүүдийн буюу.

24 Мөнхүү улиран тохиох дор, сайхан үнэрийн оронд эхүүн үнэр ханхална; мөн бүсний оронд даавууны тасархай; мөн сайхан үсний оронд халзрал; мөн цээживчний оронд самбай даавуу; түлэгдсэн шарх гоо сайхны нь оронд байх буюу.

25 Чиний эрс илдэнд мөн чиний хүчтэнүүд дайнд унах болно.

26 Мөн хотын хаалганууд гаслан чахарч; мөн хот нь балгас болон эзгүйрч, мөн тэр хөсөр суух болно.

And my people, children are their oppressors, and women rule over them. O my people, they who lead thee cause thee to err and destroy the way of thy paths.

The Lord standeth up to plead, and standeth to judge the people.

The Lord will enter into judgment with the ancients of his people and the princes thereof; for ye have eaten up the vineyard and the spoil of the poor in your houses.

What mean ye? Ye beat my people to pieces, and grind the faces of the poor, saith the Lord God of Hosts.

Moreover, the Lord saith: Because the daughters of Zion are haughty, and walk with stretched-forth necks and wanton eyes, walking and mincing as they go, and making a tinkling with their feet—

Therefore the Lord will smite with a scab the crown of the head of the daughters of Zion, and the Lord will discover their secret parts.

In that day the Lord will take away the bravery of their tinkling ornaments, and cauls, and round tires like the moon;

The chains and the bracelets, and the mufflers;

The bonnets, and the ornaments of the legs, and the headbands, and the tablets, and the ear-rings;

The rings, and nose jewels;

The changeable suits of apparel, and the mantles, and the wimples, and the crisping-pins;

The glasses, and the fine linen, and hoods, and the veils.

And it shall come to pass, instead of sweet smell there shall be stink; and instead of a girdle, a rent; and instead of well set hair, baldness; and instead of a stomacher, a girding of sackcloth; burning instead of beauty.

Thy men shall fall by the sword and thy mighty in the war.

And her gates shall lament and mourn; and she shall be desolate, and shall sit upon the ground.



## 2 Нифай 14

- 1 Мөн тэр өдөр, долоон эмэгтэй нэг эрийг барьж, хэлэх нь: бид өөрсдийнхөө талхыг идэж, мөн өөрсдийн хувцсыг өмсөх болно; зөвхөн таны нэрээр нэрлэгдэж шившгээ зайлуулахыг бидэнд зөвшөөрөөч гэцгээх болно.
- 2 Тэр өдөр Их Эзэний мөчир гоо үзэсгэлэнтэй мөн сүр жавхлантай байх болно; Израилаас зугтаж чадсан тэдэнд дэлхийн жимс онцгой сайн мөн дур булаам байх болно.
- 3 Мөнхүү улиран тохиох дор, Сионд хоцорч мөн Иерусалимд үлдсэн тэд ариун гэж нэрлэгдэх болно, Иерусалимд амьд үлдэгсдийн дунд бичигдсэн хүн бүр буюу—
- 4 Их Эзэн Сионы охидын бузар бургтийг угаан арилгасны дараа мөн Иерусалимын цусыг тэдний дундаас шүүлтийн суу билгээр мөн дүрэлзэх суу билгээр ариутгасны дараа болой.
- 5 Мөн Их Эзэн Сионы уулын оршин байх нутаг бүрийн дээр, мөн түүний чуулгануудын дээр, өдөр нь үүл манан болон утаа, мөн шөнө нь дүрэлзэх галын гэрлийг бүтээнэ; учир нь Сионы бүх алдар суугийн дээр хамгаалал байх болно.
- 6 Мөн өдөр нь халуунаас сүүдэрлэхийн тулд, мөн хоргодох газар байхын тулд, мөн шуурга борооноос халхлахын тулд асар байх болно.

## 2 Nephi 14

And in that day, seven women shall take hold of one man, saying: We will eat our own bread, and wear our own apparel; only let us be called by thy name to take away our reproach.

In that day shall the branch of the Lord be beautiful and glorious; the fruit of the earth excellent and comely to them that are escaped of Israel.

And it shall come to pass, they that are left in Zion and remain in Jerusalem shall be called holy, every one that is written among the living in Jerusalem—

When the Lord shall have washed away the filth of the daughters of Zion, and shall have purged the blood of Jerusalem from the midst thereof by the spirit of judgment and by the spirit of burning.

And the Lord will create upon every dwelling-place of mount Zion, and upon her assemblies, a cloud and smoke by day and the shining of a flaming fire by night; for upon all the glory of Zion shall be a defence.

And there shall be a tabernacle for a shadow in the daytime from the heat, and for a place of refuge, and a covert from storm and from rain.

## 2 Нифай 15

- 1 Мөн тэгээд миний ихэд хайрлах түүнд өөрийн хайртын, түүний талбайн тухай дууг дуулах буюу. Миний ихэд хайрлах түүнд үржил шимт толгойд талбай буй.
- 2 Мөн тэрээр үүнийг хүрээлэн, мөн чулуунуудыг нь цуглуулан зайлуулж, мөн үүнд хамгийн шилмэл ороонгыг тариалсан, мөн үүний дунд цамхаг барьж, мөн түүнчлэн тэнд дарс шахагчийг хийсэн; мөн тэрээр энэ нь усан үзмийг өгөх буюу хэмээн харсан, мөн энэ нь зэрлэг усан үзмийг ургуулсан болой.
- 3 Мөн эдүгээ, Ай Иерусалимын оршин суугчид, мөн Иудейн эрс, би болон миний талбайн дундах маргааныг шүүгээч, би танаас гуйя.
- 4 Ямар зүйлийг би илүүгээр өөрийн усан үзмийн талбайд хийж болох байсныг би эс хийсэн билээ? Иймийн тул, би энэ нь усан үзэм өгнө хэмээн харж байхад зэрлэг усан үзэм өгсөн билээ.
- 5 Мөн эдүгээ яв; би талбайгаа яахыг та нарт хэлье— би үүний хашаа хүрээг зайлуулна, мөн энэ нь идэгдэж устгагдах болно; мөн би үүний ханыг хэмхлэн буулгана, мөн энэ нь гишгэгдэх болно;
- 6 Мөн би үүнийг хөсөр орхисон ажгуу; энэ нь засагдаж бас сийрүүлэгдэхгүй болой; харин тэнд хатгуур мөн өргөснүүд ургах болно; түүнчлэн би үүлнүүдэд тэд үүний дээр хур бороо оруулахгүй байхыг зарлиглах болно.
- 7 Өөрөөр хэлбэл Түмний Их Эзэний талбай нь Израилын угсаа бөлгөө, мөн Иудейн эрс түүний тааламжит ургамал буюу; мөн тэрээр зөв шударга шийдвэрийг эрсэн боловч, харин түрэмгийллийг нь болгоогтун; зөв шударгыг эрэх хэдий ч, гэвч гаслан уйлахыг болгоогтун.
- 8 Энэ хорвоогийн дунд ганцаар байрлуулагдаж болохын тулд, зайгүй болтол, байр байрыг нэгтгэх тэдэнд халаг!
- 9 Түмний Их Эзэн хэлэв, миний сонорт үнэхээр олон байшин орхигдож, мөн агуу болоод үзэсгэлэнт хотууд оршин суугчидгүй болно хэмээв.
- 10 Тийм ээ, арван акр усан үзмийн талбай нэг хөнөг ургац өгөх бөлгөө, мөн ган дүүрэн үрээс торх ургац авах болно.

## 2 Nephi 15

And then will I sing to my well-beloved a song of my beloved, touching his vineyard. My well-beloved hath a vineyard in a very fruitful hill.

And he fenced it, and gathered out the stones thereof, and planted it with the choicest vine, and built a tower in the midst of it, and also made a wine-press therein; and he looked that it should bring forth grapes, and it brought forth wild grapes.

And now, O inhabitants of Jerusalem, and men of Judah, judge, I pray you, betwixt me and my vineyard.

What could have been done more to my vineyard that I have not done in it? Wherefore, when I looked that it should bring forth grapes it brought forth wild grapes.

And now go to; I will tell you what I will do to my vineyard—I will take away the hedge thereof, and it shall be eaten up; and I will break down the wall thereof, and it shall be trodden down;

And I will lay it waste; it shall not be pruned nor digged; but there shall come up briars and thorns; I will also command the clouds that they rain no rain upon it.

For the vineyard of the Lord of Hosts is the house of Israel, and the men of Judah his pleasant plant; and he looked for judgment, and behold, oppression; for righteousness, but behold, a cry.

Wo unto them that join house to house, till there can be no place, that they may be placed alone in the midst of the earth!

In mine ears, said the Lord of Hosts, of a truth many houses shall be desolate, and great and fair cities without inhabitant.

Yea, ten acres of vineyard shall yield one bath, and the seed of a homer shall yield an ephah.

11 Хүчит ундааг хайхын тулд, өглөө эртлэн босч мөн шөнө болтол үргэлжлүүлнэ, дарс тэднийг мансууруулах тэдэнд халаг!

12 Мөн босоо ятга, мөн пийпаа, хэц хэнгэрэг, мөн цоор хөгжим бас дарс тэдний найран дээр байдаг; харин тэд Их Эзэний үйлийг үл хүндлэн, мөн түүний мутраар үйлдэгдсэнийг ч анхаарах нь үгүй болой.

13 Тиймийн тул, миний хүмүүс тэд мэдлэггүйн учир боолчлолд хүрсэн болой; мөн тэдний хүндэт иргэд ч өлсөж гуринхлан, мөн тэдний ардууд цангаснаас хатсан буюу.

14 Тиймийн тул, там өөрийгөө томгосон, мөн амаа хэмжээгүй ихээр ангайж; мөн тэдний алдар суу, мөн тэдний ард олон, мөн тэдний сүр жавхлан, мөн баясах тэрээр үүнд доош орох болно.

15 Мөн ердийн нэгэн дорд үзэгдэж, мөн хүчит нэгэн даруу болгогдох болно, мөн ихэмсэг нэгний харц даруу болгогдох болно.

16 Гэвч Түмний Их Эзэн шүүлтэд өргөмжлөгдөх болно, түүнчлэн ариун Бурхан зөв шударга ёсонд ариусгагдах болно.

17 Чингээд хурганууд өөрсдийн тааваар тэжээгдэн, мөн тэжээгдэж бордогдсон тэдний орхисон нутгуудад гадныхан идээшлэх болно.

18 Дэмий хоосны оосроор алдсыг, мөн тэрэгний жолоогоор мэт нүглийг чирэх тэдэнд халаг;

19 Бид үүнийг харж болохын тулд, тэр яараг, ажлаа амжуулаг; мөн бид үүнийг мэдэж болохын тулд Израилын Ариун Нэгэний зөвлөгөө ойртож мөн ирэг хэмээн хэлэх тэдэнд буюу.

20 Сайныг муу гэх, мууг сайн гэх тэдэнд, мөн гэрлийг харанхуйгаар орлуулах, гэх тэдэнд, гашуунаар амттайг, мөн амттайгаар гашууныг орлуулах тэдэнд халаг!

21 Өөрсдийнхөө нүдэнд ухаалаг болох тэдэнд мөн өөрсдийн нүдэнд хашир гэгдэх тэдэнд халаг!

22 Дарс уухдаа хүчтэй, мөн хүчит ундааг холихдоо чадалтай хүмүүнд халаг;

23 Ёсон бусыг үйлдэгчдийг шагнуулахын тулд зөвтгөх, мөн зөв шударга хүмүүний зөв шударга үйлийн баталгааг түүнээс булаан авах тэдэнд буюу!

Wo unto them that rise up early in the morning, that they may follow strong drink, that continue until night, and wine inflame them!

And the harp, and the viol, the tabret, and pipe, and wine are in their feasts; but they regard not the work of the Lord, neither consider the operation of his hands.

Therefore, my people are gone into captivity, because they have no knowledge; and their honorable men are famished, and their multitude dried up with thirst.

Therefore, hell hath enlarged herself, and opened her mouth without measure; and their glory, and their multitude, and their pomp, and he that rejoiceth, shall descend into it.

And the mean man shall be brought down, and the mighty man shall be humbled, and the eyes of the lofty shall be humbled.

But the Lord of Hosts shall be exalted in judgment, and God that is holy shall be sanctified in righteousness.

Then shall the lambs feed after their manner, and the waste places of the fat ones shall strangers eat.

Wo unto them that draw iniquity with cords of vanity, and sin as it were with a cart rope;

That say: Let him make speed, hasten his work, that we may see it; and let the counsel of the Holy One of Israel draw nigh and come, that we may know it.

Wo unto them that call evil good, and good evil, that put darkness for light, and light for darkness, that put bitter for sweet, and sweet for bitter!

Wo unto the wise in their own eyes and prudent in their own sight!

Wo unto the mighty to drink wine, and men of strength to mingle strong drink;

Who justify the wicked for reward, and take away the righteousness of the righteous from him!

- 24 Тиймийн тул, талбайд үлдсэн сүрэлд гал авалцахын, мөн тарианы хальс хогонд дөл тархахын адилаар, тэдний үндэс өмхрөх болно, мөн тэдний дэлбээ тоос лугаа адил хатах буюу; учир юун хэмээвээс тэд Түмний Их Эзэний хуулийг хаяж, мөн Израилын Ариун Нэгэний үгийг зэвүүцсэн болой.
- 25 Тиймийн тул, Их Эзэний уур өөрийн хүмүүсийн эсрэг дүрэлзэж, мөн тэрээр мутраа тэдний эсрэг сунгаж, мөн тэднийг цохьсон бөлгөө; мөн толгод чичирч, мөн тэдний цогцсууд гудамнуудын дунд урж тасдагдсан буюу. Энэ бүгд байсан ч, уур нь зайлуулагдаагүй, харин ч түүний мутар далайсан хэвээр бөлгөө.
- 26 Мөн тэрээр алс холын үндэстнүүдэд далбаа өргөж, мөн дэлхийн хязгаарыг хүртэл тэдэнд исгэрэх болно; мөн болгоогтун, тэд хурдлан яарч ирэх болно; тэдний дунд ядрах, бүдрэх нэгээхэн ч үгүй байх болно.
- 27 Нэгээхэн ч болов нойрмог унтамхай байхгүй; бас хүү тэдний хэвлийдээ бүсэлсэн нь алдуурахгүй, тэдний шаахайн сур нь ч тасрахгүй;
- 28 Сум нь хурц байх тэдний, мөн тэдний бүх нумнууд нь хөвчлөөстэй, мөн тэдний морьдын туурай цахиур чулуу лугаа адил тооцогдох болно, мөн тэдний тэрэг нь хуй салхи мэт, тэдний архиралт нь арслан лугаа адил байх бөлгөө.
- 29 Тэд залуу арслан лугаа адил архирах болно; тийм ээ, тэд архиран, мөн олзыг барьж, тэгээд аюулгүйгээр зайлуулан зөөх болно, мөн хэн ч чөлөөлөхгүй.
- 30 Мөн тэр өдөр тэд хүрхрэх далай мэт тэдний эсрэг архирах болно; мөн хэрэв тэд газрыг харах аваас, болгоогтун, харанхуйлал бас харамсал, мөн гэрэл нь тэнгэртээ харласан байх болно.

Therefore, as the fire devoureth the stubble, and the flame consumeth the chaff, their root shall be rottenness, and their blossoms shall go up as dust; because they have cast away the law of the Lord of Hosts, and despised the word of the Holy One of Israel.

Therefore, is the anger of the Lord kindled against his people, and he hath stretched forth his hand against them, and hath smitten them; and the hills did tremble, and their carcasses were torn in the midst of the streets. For all this his anger is not turned away, but his hand is stretched out still.

And he will lift up an ensign to the nations from far, and will hiss unto them from the end of the earth; and behold, they shall come with speed swiftly; none shall be weary nor stumble among them.

None shall slumber nor sleep; neither shall the girdle of their loins be loosed, nor the latchet of their shoes be broken;

Whose arrows shall be sharp, and all their bows bent, and their horses' hoofs shall be counted like flint, and their wheels like a whirlwind, their roaring like a lion.

They shall roar like young lions; yea, they shall roar, and lay hold of the prey, and shall carry away safe, and none shall deliver.

And in that day they shall roar against them like the roaring of the sea; and if they look unto the land, behold, darkness and sorrow, and the light is darkened in the heavens thereof.

## 2 Нифай 16

- 1 Уззиа хаан нас нөгчсөн тэр жил, Их Эзэн сэнтий дээр залран буйг би түүнчлэн үзсэн, өндөрт мөн өргөгдсөн, мөн түүний хормой ариун сүмийг дүүргэсэн болно.
- 2 Үүний дээгүүр серафимууд зогсоно; тус бүр нь зургаан далавчтай бөлгөө; тэрээр хоёроор нь нүүрээ халхалж, мөн тэрээр хоёроор нь хөлөө халхалж, мөн тэрээр хоёроор нь нисдэг авай.
- 3 Мөн нэг нь нөгөөдөө хашгиран, ийн хэлэв; Түмний Их Эзэн ариун, ариун, ариун; бүх дэлхий түүний алдар суугаар дүүрэн болой.
- 4 Мөн үүдний баганууд түүний хашгирах дуугаар зайлж, мөн барилга утаагаар дүүргэгдсэн бөлгөө.
- 5 Чингээд би хэлэв: Надад хала! Би устгагдсаны улмаас болой; учир нь би цэвэр бус уруултай хүн; мөн цэвэр бус уруултай хүмүүсийн дунд би оршдог; миний нүд Хааныг, Түмний Их Эзэнийг харсны учир бөлгөө.
- 6 Чингээд серафимуудын нэг нь галын хайчаар өргөлийн тавцан дээрээс өөрийн авсан, ноцож буй цогийг гартаа аван, над уруу нисч ирэв;
- 7 Мөн тэрээр үүнийг миний аманд хүргээд, мөн хэлэв: Үз, энэ нь таны уруулд хүрсэн; мөн таны алдас зайлуулагдсан, мөн таны нүгэл ариусгагдсан.
- 8 Түүнчлэн, хэнийг би илгээх билээ; мөн хэн бидний төлөө явах билээ? хэмээх Их Эзэний дууг би сонсов. Чингээд би хэлэв: Би энд байна; намайг илгээ.
- 9 Мөн тэрээр хэлсэн нь: Яв мөн энэ хүмүүст хэл—Үнэндээ та нар сонсогтун, гэвч тэд ойлгосонгүй; мөн үнэндээ та нар харагтун, гэвч тэд ухаарсангүй.
- 10 Энэ хүмүүсийн зүрхийг хөшүүн болго, бас тэдний чихийг хатуу болго, мөн тэдний нүдийг хаа—тэд өөрсдийн нүдээр харж, мөн чихээрээ сонсож, мөн зүрх сэтгэлээрээ ойлгож, мөн өөрчлөгдөн эргэж мөн эдгээгдэх вий хэмээв—.
- 11 Чингээд би хэлэв: Их Эзэн, хэр удаан билээ? Мөн тэрээр хэлсэн нь: Хотууд оршин суугчидгүй эзгүйрч, мөн байшингууд хүнгүй, мөн газар нутаг бүрмөсөн зэлүүд болох хүртэл;

## 2 Nephi 16

In the year that king Uzziah died, I saw also the Lord sitting upon a throne, high and lifted up, and his train filled the temple.

Above it stood the seraphim; each one had six wings; with twain he covered his face, and with twain he covered his feet, and with twain he did fly.

And one cried unto another, and said: Holy, holy, holy, is the Lord of Hosts; the whole earth is full of his glory.

And the posts of the door moved at the voice of him that cried, and the house was filled with smoke.

Then said I: Wo is unto me! for I am undone; because I am a man of unclean lips; and I dwell in the midst of a people of unclean lips; for mine eyes have seen the King, the Lord of Hosts.

Then flew one of the seraphim unto me, having a live coal in his hand, which he had taken with the tongs from off the altar;

And he laid it upon my mouth, and said: Lo, this has touched thy lips; and thine iniquity is taken away, and thy sin purged.

Also I heard the voice of the Lord, saying: Whom shall I send, and who will go for us? Then I said: Here am I; send me.

And he said: Go and tell this people—Hear ye indeed, but they understood not; and see ye indeed, but they perceived not.

Make the heart of this people fat, and make their ears heavy, and shut their eyes—lest they see with their eyes, and hear with their ears, and understand with their heart, and be converted and be healed.

Then said I: Lord, how long? And he said: Until the cities be wasted without inhabitant, and the houses without man, and the land be utterly desolate;

12 Мөн Их Эзэн хүмүүсийг алс хол нүүлгэх болой,  
агуу их эзгүйрэл уг нутагт байхын учир бөлгөө.

13 Гэвч тэр үед арваас нэг нь үлдэх болно, мөн тэд эргэж ирэх болно, мөн навчсаа гээсэн ч гол нь амьд байх далдуу лугаа адил, мөн царс лугаа адил идэгдэх болно; тийн ариун үр түүний амь байх болно.

And the Lord have removed men far away, for there shall be a great forsaking in the midst of the land.

But yet there shall be a tenth, and they shall return, and shall be eaten, as a teil tree, and as an oak whose substance is in them when they cast their leaves; so the holy seed shall be the substance thereof.

## 2 Нифай 17

- 1 Мөнхүү улиран тохиох дор Уззиагийн хүү болох Иофамын хүү Иудейн хаан Ахазын өдрүүдэд, Сирийн хаан болох тэр Резин, мөн Ремалиагийн хүү Израилын хаан Пека, Иерусалимын эсрэг дайтахаар түүний зүг одов, гэвч үүнийг ялж эс чадав.
- 2 Мөн энэ нь Давидын угсаанд хэлэгдсэн бөлгөө, хэлрүүн: Сири нь Ефраимтай хуйвалдах болой. Мөн түүний зүрх сэтгэл хөдөлсөн, мөн түүний хүмүүсийн зүрх, ургаа мод салхинд хөдөлдөг лугаа адил бөлгөө.
- 3 Чингээд Их Эзэн Исаиад хэлэв: Ахазтай уулзахаар эдүгээ урагш од, та болон таны хүү Шиержашуб, угаагчийн талбайн их замд байх дээд усан сангийн сувгийн төгсгөл тийш буюу.
- 4 Мөн түүнд хэл: Болгоомжтой бай, мөн нам гүм бай, эдгээр утаа манарах галт цуцлуудын хоёр үзүүрээс бүү эмээгтүн, бас битгий зүрх алд, Сирийн Резин мөн түүний хүү Ремалиа нарын догшин хилэнгийн учир бөлгөө.
- 5 Учир нь Сири, Ефраим мөн Ремалиагийн хүү таны эсрэг ёс бус зөвлөлдөв, үүнд:
- 6 Бүгдээр Иудейн эсрэг явж, мөн түүнийг өдөөе, мөн үүнд өөрсдийн төлөө эвдрэлийг үүдэж, мөн үүний дунд хаан тохооё, тийм ээ, Табиелын хүүг буюу.
- 7 Их Эзэн Бурхан ийн хэлэв: Энэ нь бүтэхгүй, мөн улиран тохиох нь ч үгүй болой.
- 8 Тухайлбал Сирийн тэргүүн Дамаск, мөн Дамаскийн тэргүүн Резин, мөн жаран таван жилд Ефраим улс үгүй болж эвдлэгдэх бөлгөө.
- 9 Мөн Ефраимын тэргүүн Самари, мөн Самарийн тэргүүн нь Ремалиагийн хүү билээ. Хэрэв та нар итгэхгүй аваас, та нар хамгаалагдахгүй нь магад.
- 10 Үүнээс гадна, Их Эзэн Ахазад дахин ярьж, хэлсэн нь:
- 11 Их Эзэн, Бурханаасаа нэгэн тэмдэг гуй; гүн гүнзгийд, эсвээс дээр өндөрт үүнийг гуй.
- 12 Харин Ахаз хэлэв: Би гуйх нь үгүй, бас Их Эзэнийг би сорих нь үгүй.
- 13 Мөнхүү тэрээр хэлэв: Эдүгээ та нар сонс, Ай Давидын угсаа; хүмүүнийг ядраах нь та нарт бага зүйл үү, харин та нар түүнчлэн Бурханыг минь ядраах гэж үү

## 2 Nephi 17

And it came to pass in the days of Ahaz the son of Jotham, the son of Uzziah, king of Judah, that Rezin, king of Syria, and Pekah the son of Remaliah, king of Israel, went up toward Jerusalem to war against it, but could not prevail against it.

And it was told the house of David, saying: Syria is confederate with Ephraim. And his heart was moved, and the heart of his people, as the trees of the wood are moved with the wind.

Then said the Lord unto Isaiah: Go forth now to meet Ahaz, thou and Shearjashub thy son, at the end of the conduit of the upper pool in the highway of the fuller's field;

And say unto him: Take heed, and be quiet; fear not, neither be faint-hearted for the two tails of these smoking firebrands, for the fierce anger of Rezin with Syria, and of the son of Remaliah.

Because Syria, Ephraim, and the son of Remaliah, have taken evil counsel against thee, saying:

Let us go up against Judah and vex it, and let us make a breach therein for us, and set a king in the midst of it, yea, the son of Tabeal.

Thus saith the Lord God: It shall not stand, neither shall it come to pass.

For the head of Syria is Damascus, and the head of Damascus, Rezin; and within threescore and five years shall Ephraim be broken that it be not a people.

And the head of Ephraim is Samaria, and the head of Samaria is Remaliah's son. If ye will not believe surely ye shall not be established.

Moreover, the Lord spake again unto Ahaz, saying:

Ask thee a sign of the Lord thy God; ask it either in the depths, or in the heights above.

But Ahaz said: I will not ask, neither will I tempt the Lord.

And he said: Hear ye now, O house of David; is it a small thing for you to weary men, but will ye weary my God also?

14 Тиймийн тул, Их Эзэн өөрөө та нарт тэмдэг өгөх болно—Болгоогтун, онгон бүсгүй хөл хүндтэй болно, мөн хүү төрүүлж, мөн түүний нэрийг Иммануел гэж дуудах болно.

15 Тэрээр цөцгийн тос, бал иднэ, тэр хилэнцтээс татгалзаж мөн сайныг сонгохыг мэдэж болохын тулд буюу.

16 Учир нь уг хүүхэд хилэнцтээс татгалзаж мөн сайныг сонгож мэдэхээс урьд, таны жигшдэг тэр нутаг, хоёр хаанд хоёуланд нь хаягдах болно.

17 Их Эзэн таны дээр, мөн таны хүмүүсийн дээр, мөн таны эцгийн отгийн дээр Ефраим Иудейгаас зайлсан тэр өдрөөс хойш ирээгүй тэр өдрүүдийг, Ассирийн хааныг авчрах болно.

18 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Египетийн хамгийн алс хэсэг дэх ялааг, мөн Ассирийн нутагдахь зөгийг исгэрэн дуудах болно.

19 Мөн тэд ирэх болно, мөн тэд бүгд зэлүүд хөндийн дээр, мөн хадны хонгилд, мөн бүх өргөс, мөн бүх бутнуудын дээр амсхийх болно.

20 Мөн тэрхүү өдөр Их Эзэн голын цаадах тэднээр, Ассирийн хаанаар хөлслөгдсөн сахлын хутгаар, толгойг, мөн хөлийн үсийг хусуулах болно; мөн энэ нь түүнчлэн сахлыг ч авах болно.

21 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр, нэгэн хүн залуу үнээ мөн хоёр хонийг тэжээх болно.

22 Мөнхүү улиран тохиох дор, тэдгээрийн өгөх элбэг их сүүний тул тэрээр цөцгийн тос идэх болно; өөрөөр хэлбэл цөцгийн тос болон балыг уг нутагт үлдсэн хүн бүр идэх болно.

23 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр, мянган мөнгөн зоосны үнэ бүхий, мянган усан үзмийн ороонго байсан тэнд, газар бүрд өргөст бут мөн хатгуур байх болно.

24 Хүмүүс нь нум сум агсан тэнд ирэх болно, бүх нутаг өргөст бут болон хатгуур болохын учир болой.

25 Мөн зээтүүнд сэндийлэгдэх бүх толгодод, тэнд өргөст бут болон хатгуураас айх айдас байх нь үгүй; харин энэ нь шар үхэр туух газар, мөн бага малын бэлчээр байх болно.

Therefore, the Lord himself shall give you a sign— Behold, a virgin shall conceive, and shall bear a son, and shall call his name Immanuel.

Butter and honey shall he eat, that he may know to refuse the evil and to choose the good.

For before the child shall know to refuse the evil and choose the good, the land that thou abhorrest shall be forsaken of both her kings.

The Lord shall bring upon thee, and upon thy people, and upon thy father's house, days that have not come from the day that Ephraim departed from Judah, the king of Assyria.

And it shall come to pass in that day that the Lord shall hiss for the fly that is in the uttermost part of Egypt, and for the bee that is in the land of Assyria.

And they shall come, and shall rest all of them in the desolate valleys, and in the holes of the rocks, and upon all thorns, and upon all bushes.

In the same day shall the Lord shave with a razor that is hired, by them beyond the river, by the king of Assyria, the head, and the hair of the feet; and it shall also consume the beard.

And it shall come to pass in that day, a man shall nourish a young cow and two sheep;

And it shall come to pass, for the abundance of milk they shall give he shall eat butter; for butter and honey shall every one eat that is left in the land.

And it shall come to pass in that day, every place shall be, where there were a thousand vines at a thousand silverlings, which shall be for briers and thorns.

With arrows and with bows shall men come thither, because all the land shall become briers and thorns.

And all hills that shall be digged with the mattock, there shall not come thither the fear of briers and thorns; but it shall be for the sending forth of oxen, and the treading of lesser cattle.



## 2 Нифай 18

- 1 Үүнээс гадна, Их Эзэний үг надад хэлсэн нь: Их ботийг ав чи, мөн хүмүүний үзгээр үүн дээр бич, Махер-шалал-хаш-базын талаар буюу.
- 2 Мөн би өөртөө итгэлтэй гэрчүүдийг цэдгүүд хөтлүүлэхээр авсан бөлгөө, санваартан Уриа, мөн Иеберекиагийн хүү Зехариаг буюу.
- 3 Мөн би бошиглогч эмэгтэйд очив; мөн тэрээр бие давхар болж мөн хүү төрүүлэв. Чингээд Их Эзэн надад хэлэв: Түүний нэрийг Махер-шалал-хаш-баз хэмээн дууд.
- 4 Учир нь болгоогтун, Дамаскийн баялаг болон Самарийн олз Ассирын хааны өмнө аваачигдахаас урьд уг хүүхэд аав минь, мөн ээж минь гэж хашгирах мэдлэггүй байх болой.
- 5 Их Эзэн түүнчлэн надад дахин ярьж, хэлсэн нь:
- 6 Энэ хүмүүс зөөлөн урсгалт Шилогийн уснаас татгалзана, мөн Резинд болон Ремалиагийн хүүд баясахын хэрээр буюу;
- 7 Эдүгээ тиймийн тул, болгоогтун, Их Эзэн тэдний дээр голын хүчит их усыг авчирна, бүр Ассирийн хаан мөн түүний бүх сүр жавхланг буюу; мөн энэ нь бүх суваг шуудуугаа хальж, мөн бүх эргээ даван ирэх болно.
- 8 Мөн тэрээр Иудейг гатлах болно, энэ нь үерлэж мөн халих болно, энэ нь бүр хүзүүгээр татах болно; мөн үүний хаялах давалгаа нутгийн чинь энг дүүргэх болно, Ай Иммануел.
- 9 Өөрсдийгөө нэгтгэцгээ, Ай хүмүүс та нар, мөн та нар хэдэн хэсэг тасчигдах болно; мөн алс нутгийн та нар бүгд чих тавьцгаа; өөрсдийгөө хуяглацгаа, мөн та нар хэдэн хэсэг тасчигдах болно.
- 10 Хамтран зөвлөцгөө, мөн энэ нь юунд ч хүргэхгүй болой; үг хэлэлц, мөн энэ нь тогтсоноор болохгүй; учир нь Бурхан бидэнтэй хамт байгаа.
- 11 Учир нь Их Эзэн чингээд надад хүчтэйгээр ярьж мөн би энэ хүмүүсийн замаар алхах ёсгүйг надад зааварлан, хэлсэн нь:
- 12 Та нар энэ хүмүүсийн Хуйвалдаан гэж хэлэх тэр бүгдэд Хуйвалдаан хэмээн бүү хэл; тэдний айснаас бүү ай, бас бүү эмээгтүн.

## 2 Nephi 18

Moreover, the word of the Lord said unto me: Take thee a great roll, and write in it with a man's pen, concerning Maher-shalal-hash-baz.

And I took unto me faithful witnesses to record, Uriah the priest, and Zechariah the son of Jeberechiah.

And I went unto the prophetess; and she conceived and bare a son. Then said the Lord to me: Call his name, Maher-shalal-hash-baz.

For behold, the child shall not have knowledge to cry, My father, and my mother, before the riches of Damascus and the spoil of Samaria shall be taken away before the king of Assyria.

The Lord spake also unto me again, saying:

Forasmuch as this people refuseth the waters of Shiloah that go softly, and rejoice in Rezin and Remaliah's son;

Now therefore, behold, the Lord bringeth up upon them the waters of the river, strong and many, even the king of Assyria and all his glory; and he shall come up over all his channels, and go over all his banks.

And he shall pass through Judah; he shall overflow and go over, he shall reach even to the neck; and the stretching out of his wings shall fill the breadth of thy land, O Immanuel.

Associate yourselves, O ye people, and ye shall be broken in pieces; and give ear all ye of far countries; gird yourselves, and ye shall be broken in pieces; gird yourselves, and ye shall be broken in pieces.

Take counsel together, and it shall come to naught; speak the word, and it shall not stand; for God is with us.

For the Lord spake thus to me with a strong hand, and instructed me that I should not walk in the way of this people, saying:

Say ye not, A confederacy, to all to whom this people shall say, A confederacy; neither fear ye their fear, nor be afraid.

13 Түмний Их Эзэнийг өөрийг нь алдаршуулцгаа,  
мөн та нарын айдас тэр байг, мөн та нарын сүрдэх нь  
тэр байг.

14 Мөн тэрээр дуган мэт байх болно; гэвч Израилын  
хоёр угсаанд хоёуланд нь тээглэх чулуу, мөн дур-  
гүйцлийн хад мэт байх болно, Иерусалимын оршин  
суугчдад занга мөн урхи байх болно.

15 Мөн тэдний дундаас олон нь тээглэж бас унана,  
мөн хэмхлэгдэж, мөн урхидагдаж бас баривчлагдах  
болно.

16 Миний шавь нарын дунд гэрчлэлийг баринтагла,  
хуулийг лацад.

17 Мөн Иаковын угсаанаас нүүрээ буруулсан тэр Их  
Эзэнд хандан би хүлээх болно, мөн би түүнийг ха-  
руулдах болно.

18 Болгоогтун, Сионы ууланд орших Түмний Их  
Эзэнээс Израилд тэмдгүүд болон гайхамшгууд бол-  
госон нь би, түүнчлэн Их Эзэн надад өгсөн хүүхдүүд  
буюу.

19 Мөн тэд чамд: Танил сүнс бүхий тэднээс хай, мөн  
дуудагч мөн бувтналдан үглэх илбэчид болох тэд-  
нээс хай хэмээн хэлэх үед—амьд хүмүүс үхэгсдээс  
сонсохын тулд Бурханаасаа хайхэсгүй гэж үү

20 Хуулиас мөн гэрчлэлээс; мөн хэрэв тэд энэ үгийн  
дагуу ярихгүй аваас, энэ нь тэдэнд гэрэл үгүйн учир  
болой.

21 Мөн тэд үүнийг туулахдаа хатуу бэрх бэрхшээл  
мөн өлсгөлөнг үзнэ; мөн улиран тохиох дор тэд өл-  
сөх үедээ, тэд өөрсдийгөө уурлуулан зовоож, мөн  
дээш хандан Хаанаа мөн Бурханаа зүхэх болно.

22 Мөн тэд газарт хандаж мөн бэрхшээл, мөн харан-  
хуй, зовлонгийн мананг харах болно, тэгээд харан-  
хуй тийш туугдах болно.

Sanctify the Lord of Hosts himself, and let him be  
your fear, and let him be your dread.

And he shall be for a sanctuary; but for a stone of  
stumbling, and for a rock of offense to both the houses  
of Israel, for a gin and a snare to the inhabitants of  
Jerusalem.

And many among them shall stumble and fall, and be  
broken, and be snared, and be taken.

Bind up the testimony, seal the law among my disci-  
ples.

And I will wait upon the Lord, that hideth his face  
from the house of Jacob, and I will look for him.

Behold, I and the children whom the Lord hath  
given me are for signs and for wonders in Israel from the  
Lord of Hosts, which dwelleth in Mount Zion.

And when they shall say unto you: Seek unto them  
that have familiar spirits, and unto wizards that peep  
and mutter—should not a people seek unto their God  
for the living to hear from the dead?

To the law and to the testimony; and if they speak  
not according to this word, it is because there is no light  
in them.

And they shall pass through it hardly bestead and  
hungry; and it shall come to pass that when they shall  
be hungry, they shall fret themselves, and curse their  
king and their God, and look upward.

And they shall look unto the earth and behold trou-  
ble, and darkness, dimness of anguish, and shall be  
driven to darkness.

## 2 Нифай 19

- 1 Гэсэн хэдий ч, эхлээд тэрээр Зебулуны нутаг мөн Нафталын нутгийг хөнгөн зүдрээж, мөн дараа нь Улаан тэнгисийн замд, Иордан голын цаана үндэстнүүдийг Галилд илүү эмгэнэлтэйгээр зовоосон үеийнх нь, уг манан түүний дургүйцэлд байсан лугаа адил тийм байхгүй болой.
- 2 Харанхуйд алхдаг байсан хүмүүс агуу гэрлийг харсан аж; үхлийн сүүдэр татсан нутагт орших, тэдний дээр уг гэрэл туссан буюу.
- 3 Та үндэстнийг үржүүлж мөн баяслыг нэмсэн— тэд таны өмнө ургацын баярын үеийнх мэт баясна, мөн эрчүүд тэд олзоо хуваахдаа баярлах лугаа адил болой.
- 4 Учир нь мөн түүний дарангуйллын буулгыг, мөн түүний мөрөн дээрх дарамтыг, түүний дарлагчийн савааг та хэмхэлсэн бөлгөө.
- 5 Тухайлбал дайчны тулаан бүр нь эх захгүй шуугиантай байж, мөн өмсгөл нь цусанд нэвчсэн байдаг; гэвч энэ нь түймэр мөн галын түлшний дунд байх болно.
- 6 Тухайлбал хүүхэд бидний тул төрсөн, бидэнд хүү өгөгдсөн; мөн засаг захиргаа нь түүний мөрөн дээр байх болно; мөн түүний нэр нь Гайхамшигт, Зөвлөгч, Хүчит Бурхан, Үүрдийн Эцэг, Энх Амгалангийн Ханхүү хэмээн дуурсах болно.
- 7 Давидын сэнтий дээр, мөн үүнийг журамлан мөн үүнийг шударга байдал болон шударга ёсоор энэ цагаас эхлэн, бүр үүрд тогтоохын тулд түүний хаант улсын дээр засаглалын мөн амар амгалангийн өсөлт төгсгөлгүй байна. Түмний Их Эзэний хичээл зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно.
- 8 Их Эзэн өөрийн үгийг Иаковт илгээж, мөн энэ нь Израилын дээр тогтсон бөлгөө.
- 9 Мөн бүх хүмүүс мэдэх болно, бүр Ефраим болон Самарийн оршин суугчид бардам мөн бөх зүрхтэйгээр хэлдэг:
- 10 Тоосгонууд доош унасан, гэвч бид зассан чулуугаар барих болно; цагаан агч мод тайрагдан унасан, гэвч бид тэдгээрийг хуш модоор орлуулах болно хэмээсэн тэд буюу.

## 2 Nephi 19

Nevertheless, the dimness shall not be such as was in her vexation, when at first he lightly afflicted the land of Zebulun, and the land of Naphtali, and afterwards did more grievously afflict by the way of the Red Sea beyond Jordan in Galilee of the nations.

The people that walked in darkness have seen a great light; they that dwell in the land of the shadow of death, upon them hath the light shined.

Thou hast multiplied the nation, and increased the joy—they joy before thee according to the joy in harvest, and as men rejoice when they divide the spoil.

For thou hast broken the yoke of his burden, and the staff of his shoulder, the rod of his oppressor.

For every battle of the warrior is with confused noise, and garments rolled in blood; but this shall be with burning and fuel of fire.

For unto us a child is born, unto us a son is given; and the government shall be upon his shoulder; and his name shall be called, Wonderful, Counselor, The Mighty God, The Everlasting Father, The Prince of Peace.

Of the increase of government and peace there is no end, upon the throne of David, and upon his kingdom to order it, and to establish it with judgment and with justice from henceforth, even forever. The zeal of the Lord of Hosts will perform this.

The Lord sent his word unto Jacob and it hath lighted upon Israel.

And all the people shall know, even Ephraim and the inhabitants of Samaria, that say in the pride and stoutness of heart:

The bricks are fallen down, but we will build with hewn stones; the sycamores are cut down, but we will change them into cedars.

11 Тиймийн тул Их Эзэн Резиний өрсөлдөгчдийг түүний эсрэг тавих болно, мөн түүний дайснуудыг нэгтгэн хамтатгах буюу;

12 Эхлээд Сирийнхэн тэгээд хойно нь Филистинийхэн; мөн тэд Израилыг ангайсан амаараа үмхлэх болно. Энэ бүгд байсан ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч гар нь далайсан хэвээр болой.

13 Учир нь хүмүүс өөрсдийг нь жанчих түүнд хандахгүй, бас тэд Түмний Их Эзэнийг ч үл хайх бөлгөө.

14 Тиймийн тул Их Эзэн Израилаас нэгэн өдөр толгой мөн сүүлийг, мөчир болон салааг огтлон авах болно.

15 Ахмад нэгэн, тэр нь толгой; мөн худал хуурмагийг сургах бошиглогч, тэр нь сүүл буюу.

16 Өөрөөр хэлбэл энэ хүмүүсийн удирдагчид тэднийг гажуудуулна; мөн тэднээр удирдагдсан тэд устгагдах болно.

17 Тиймийн тул Их Эзэн тэдний залуу эрчүүдэд баясах нь үгүй, бас тэдний эцэггүй болон бэлэвсэнд нигүүлсэл үгүй байх болно; учир нь тэдний хүн бүр нь хоёр нүүртэн мөн хилэнцийг үйлдэгч мөн ам болгон мунхгийг ярих бөлгөө. Энэ бүгд болсон ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч түүний гар далайсан хэвээр болой.

18 Өөрөөр хэлбэл ёсон бус нь гал лугаа адил шатна; энэ нь өргөс болон хатгууруудыг залгина, мөн ойн өтгөн шигүүд нь асах болно, мөн угаа дээш хөөрөх лугаа адил тэд замхрах болно.

19 Түмний Их Эзэний хилэнгээр уг нутаг харанхуйлагдан, мөн тэр хүмүүс галын түлш лугаа адил байх болно; хэн ч ахан дүүсээ хэлтрүүлэх нь үгүй болой.

20 Мөн тэрээр баруун гартаа шүүрэх боловч мөн өлсгөлөн байна; мөн тэрээр зүүн гардахаа идэх болно мөн тэд ханах нь үгүй; тэд идэх болно, хүн бүр шууныхаа махыг буюу—

21 Манассе Ефраим; мөн Ефраим Манассе; тэд хамтдаа Иудейн эсрэг байх болно. Энэ бүгд болсон ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч түүний гар далайсан хэвээр байгаа.

Therefore the Lord shall set up the adversaries of Rezin against him, and join his enemies together;

The Syrians before and the Philistines behind; and they shall devour Israel with open mouth. For all this his anger is not turned away, but his hand is stretched out still.

For the people turneth not unto him that smiteth them, neither do they seek the Lord of Hosts.

Therefore will the Lord cut off from Israel head and tail, branch and rush in one day.

The ancient, he is the head; and the prophet that teacheth lies, he is the tail.

For the leaders of this people cause them to err; and they that are led of them are destroyed.

Therefore the Lord shall have no joy in their young men, neither shall have mercy on their fatherless and widows; for every one of them is a hypocrite and an evil-doer, and every mouth speaketh folly. For all this his anger is not turned away, but his hand is stretched out still.

For wickedness burneth as the fire; it shall devour the briers and thorns, and shall kindle in the thickets of the forests, and they shall mount up like the lifting up of smoke.

Through the wrath of the Lord of Hosts is the land darkened, and the people shall be as the fuel of the fire; no man shall spare his brother.

And he shall snatch on the right hand and be hungry; and he shall eat on the left hand and they shall not be satisfied; they shall eat every man the flesh of his own arm—

Manasseh, Ephraim; and Ephraim, Manasseh; they together shall be against Judah. For all this his anger is not turned away, but his hand is stretched out still.

## 2 Нифай 20

- 1 Зөв бус тогтоолыг тогтоох, мөн өөрсдийн зохиосон дарамтыг бичих тэдэнд халаг;
- 2 Бэлэвсэн нь тэдний олз байх болно, мөн тэд эцэггүйг дээрэмдэж болохын тулд хэрэгцээтэйг шударга ёсноос салгана, мөн миний хүмүүсийн ядуугаас эрхийг нь булаан авах тэдэнд буюу!
- 3 Мөн айлчлалын уг өдөр, мөн холоос ирэх тэрхүү хоосролын үед та нар юу хийх билээ? Хэнд та нар тусламж авахаар харайж очих билээ? Мөн та нар сүр хүчээ хаана орших билээ
- 4 Надгүйгээр тэд хоригдлуудын дор ч бөхөлзөх болно, мөн тэд алагдсаны дор унах болно. Энэ бүгд болсон ч түүний хилэн зайлуулагдаагүй, харин ч түүний гар далайсан хэвээр байгаа.
- 5 Ай Ассирийнхан, миний уур хилэнгийн саваа, мөн тэдний гарт байх таяг нь тэдний зэвүүцэл болой.
- 6 Би түүнийг хоёр нүүртэн үндэстний эсрэг илгээх болно, мөн би өөрийн хилэнгэсэн хүмүүст олзыг авч, мөн идшийг нь булаах, мөн тэднийг гудамжны балчиг шавхай лугаа адил доороо гишгэчих үүрэгийг түүнд өгөх болно.
- 7 Хэдий тийм ч, тэрээр ийн санасан нь үгүй, түүний зүрх сэтгэл ч бас тийн бодсон нь үгүй; гэвч тэр зүрх сэтгэлдээ цөөн биш үндэстнүүдийг устгаж мөн тусгаарлах буйза.
- 8 Өөрөөр хэлбэл тэрээр: Миний хунтайжууд бүхэлдээ хаадууд бус уу? хэмээв.
- 9 Кално нь Карчимиш шиг бус уу? Хамаф нь Арпад шиг бус уу? Самари нь Дамаск шиг бус уу
- 10 Миний гар хиймэл шүтээнүүдийн хаант улсуудыг үндэслэсний адилаар, мөн тэдний зормол дүрсүүд Иерусалимын болон Самарийнхаас нэтэд илүү тэдгээрийг буюу;
- 11 Би Самарид мөн түүний хиймэл шүтээнүүдэд үйлдсэний адилаар, Иерусалимд мөн түүний хиймэл шүтээнүүдэд тийн үйлдэх минь үгүй гэж үү
- 12 Иймийн тул улиран тохиох дор Их Эзэн, Сионы Уулан дээр мөн Иерусалим дээр өөрийн бүхий л ажлыг гүйцэтгэсний дараа, би Ассирийн хааны бөх зүрхтэйн үрийг мөн түүний дээгүүр харах сүр жавхланг нь шийтгэх болно хэмээв.

## 2 Nephi 20

- Wo unto them that decree unrighteous decrees, and that write grievousness which they have prescribed;
- To turn away the needy from judgment, and to take away the right from the poor of my people, that widows may be their prey, and that they may rob the fatherless!
- And what will ye do in the day of visitation, and in the desolation which shall come from far? to whom will ye flee for help? and where will ye leave your glory?
- Without me they shall bow down under the prisoners, and they shall fall under the slain. For all this his anger is not turned away, but his hand is stretched out still.
- O Assyrian, the rod of mine anger, and the staff in their hand is their indignation.
- I will send him against a hypocritical nation, and against the people of my wrath will I give him a charge to take the spoil, and to take the prey, and to tread them down like the mire of the streets.
- Howbeit he meaneth not so, neither doth his heart think so; but in his heart it is to destroy and cut off nations not a few.
- For he saith: Are not my princes altogether kings?
- Is not Calno as Carchemish? Is not Hamath as Arpad? Is not Samaria as Damascus?
- As my hand hath founded the kingdoms of the idols, and whose graven images did excel them of Jerusalem and of Samaria;
- Shall I not, as I have done unto Samaria and her idols, so do to Jerusalem and to her idols?
- Wherefore it shall come to pass that when the Lord hath performed his whole work upon Mount Zion and upon Jerusalem, I will punish the fruit of the stout heart of the king of Assyria, and the glory of his high looks.

13 Өөрөөр хэлбэл тэрээр хэлсэн нь: Өөрийн гарын хүчээр мөн өөрийн ухаанаар би эдгээр зүйлийг хийсэн бөлгөө; учир нь би бол хэрсүү хашир нэгэн; мөн би ард олны хил хязгааруудыг зөөсөн, мөн тэдний үнэтэйг дээрэмдэж, мөн би баатар хүн лугаа адил оршин суугчдыг нь дорд болгосон билээ;

14 Мөн миний мутар шувууны үүрэнд орсон мэт хүмүүсийн баялгийг олсон болой; мөн үлдсэн өндгүүдийг хураах нэгэн мэт би бүх дэлхийг хураав; мөн нэгээхэн нь ч далавчаа хөдөлгөж, эсвээс уруул нээж, эсвээс бувтнасан нь үгүй бөлгөө.

15 Түүгээр цавчих хүний эсрэг сүх өөрөөрөө бардамнах гэж үү? Үүнийг хөдөлгөгч түүний эсрэг хөрөө өөрөө ихэрхэх гэж үү? Торлог өөрөө үүнийг өргөсөн тэдний эсрэг сэгсэрдэг бил үү, эсвээс таяг модон биш юм шиг өөрийгөө өргөдөг бил үү!

16 Тиймийн тул Их Эзэн, Түмний Их Эзэн түүний өөгшүүлэгдсэн хүмүүсийн дунд, гарчгийг илгээнэ; мөн түүний сүр хүчнийх нь доор тэрээр дүрэлзэх түймэр лугаа адил асаах болно.

17 Мөн Израилын гэрэл нь түймэр, мөн түүний Ариун Нэгэн бамбар байх болно, мөн түүний өргөс мөн түүний хатгууруудыг нэг өдөрт залгиж мөн шатах болно;

18 Мөн түүний шимт талбайн мөн түүний ойн сүр жавхланг цөлмөх болно, сүнс болон биеийг аль алиныг нь буюу; мөн тэд тугч нь туйлдсан мэт байх болно.

19 Мөн түүний ойгоос үлдсэн модод нь хүүхэд ч тэдгээрийг тоолж болохоор цөөн байх болно.

20 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр, Иаковын угсаанаас тэсэж давсан тэд болон Израилын үлдэгдэл нь, өөрсдийг нь цохьсон түүнд дахин нэгээхэн ч түшиглэхгүй, харин Израилын Ариун Нэгэнд, Их Эзэнд үнэнчээр түшиглэх болно.

21 Үлдэгдэл нь, тийм ээ, бүр Иаковын үлдэгдэл нь, хүчит Бурханд эргэж ирэх болно.

22 Өөрөөр хэлбэл Израил-чиний хүмүүс тэнгисийн элсний ширхэг мэт байх болно, тийм хэдий ч тэдний үлдэгдэл эргэж ирэх болно; уг тогтоогдсон гарз нь зөв шударгыг халгилуулах болно.

23 Өөрөөр хэлбэл Түмний Их Эзэн Бурхан гарзыг устгах болно, бүр бүх нутагт шийдэгдсэн буюу.

For he saith: By the strength of my hand and by my wisdom I have done these things; for I am prudent; and I have moved the borders of the people, and have robbed their treasures, and I have put down the inhabitants like a valiant man;

And my hand hath found as a nest the riches of the people; and as one gathereth eggs that are left have I gathered all the earth; and there was none that moved the wing, or opened the mouth, or peeped.

Shall the ax boast itself against him that heweth therewith? Shall the saw magnify itself against him that shaketh it? As if the rod should shake itself against them that lift it up, or as if the staff should lift up itself as if it were no wood!

Therefore shall the Lord, the Lord of Hosts, send among his fat ones, leanness; and under his glory he shall kindle a burning like the burning of a fire.

And the light of Israel shall be for a fire, and his Holy One for a flame, and shall burn and shall devour his thorns and his briers in one day;

And shall consume the glory of his forest, and of his fruitful field, both soul and body; and they shall be as when a standard-bearer fainteth.

And the rest of the trees of his forest shall be few, that a child may write them.

And it shall come to pass in that day, that the remnant of Israel, and such as are escaped of the house of Jacob, shall no more again stay upon him that smote them, but shall stay upon the Lord, the Holy One of Israel, in truth.

The remnant shall return, yea, even the remnant of Jacob, unto the mighty God.

For though thy people Israel be as the sand of the sea, yet a remnant of them shall return; the consumption decreed shall overflow with righteousness.

For the Lord God of Hosts shall make a consumption, even determined in all the land.

24 Тиймийн тул, Түмний Их Эзэн Бурхан тийн хэлнэ: Ай Сионд орших миний хүмүүс ээ, ассиричуудаас битгий ай; тэр та нарыг саваагаар цохих болно, мөн египетчүүдийн нэгэн адилаар, та нарын эсрэг таягаа далайх болно.

25 Багахан хугацааны дараа, мөн зэвүүцэл зогсох болно, мөн миний уур хилэн тэдний устгалд ч болой.

26 Мөн Түмний Их Эзэн Оребын хадан дээрх Мидианы аллагын дагуу түүний төлөө цээрлэлийг өдөөх болно; мөн түүний саваа тэнгисийн дээр байсны адил тэрээр үүнийг Египетийн маягаар далайх болно.

27 Мөнхүү улиран тохиох дор түүний үүрэг чиний мөрөн дээрээс ховхорно, мөн түүний буулга чиний хүзүүнээс чинь мулгарч уг буулга тослолтын учир устгагдах тэр өдөр болно.

28 Тэрээр Аиафт ирж, тэр нь Мигроныг туулсан болой; Мичмашид тэр хөсгөө буулгасан болой.

29 Тэд хөтлийг даван одов; тэд Гебад өөрсдийн байрлалыг эзэгнэн авсан ажгуу; Рамаф эмээж буй; Саулын Гибча зугтсан буюу.

30 Дуугаа өргө, Ай Галлимьн охин; Лаишид сонсго, Ай хөөрхий Анафоф.

31 Мадмена зайлуулагдсан буюу; Гебимийн оршин суугчид зугтахаар өөрсдөө цуглацгааж байна.

32 Одоогийн адил тэр өдөр тэрээр Нобад үлдэх болой; тэрээр мутраа Сионы охины уул, Иерусалимын толгодын эсрэг сэгсрэх болно.

33 Болгоогтун, Их Эзэн, Түмний Их Эзэн гишүүт аймшигтайгаар тас цавчих болно; мөн өндрийн улмаас дээр байгч нь доош тас чавчигдах болно; мөн ихэмсгүүд даруусг агдах болно.

34 Мөн тэрээр ойн өтгөнийг төмрөөр тасчин буулгах болно, мөн Ливан хүчит нэгнээр унагаагдах болно.

Therefore, thus saith the Lord God of Hosts: O my people that dwellest in Zion, be not afraid of the Assyrian; he shall smite thee with a rod, and shall lift up his staff against thee, after the manner of Egypt.

For yet a very little while, and the indignation shall cease, and mine anger in their destruction.

And the Lord of Hosts shall stir up a scourge for him according to the slaughter of Midian at the rock of Oreb; and as his rod was upon the sea so shall he lift it up after the manner of Egypt.

And it shall come to pass in that day that his burden shall be taken away from off thy shoulder, and his yoke from off thy neck, and the yoke shall be destroyed because of the anointing.

He is come to Aiath, he is passed to Migron; at Michmash he hath laid up his carriages.

They are gone over the passage; they have taken up their lodging at Geba; Ramath is afraid; Gibeah of Saul is fled.

Lift up the voice, O daughter of Gallim; cause it to be heard unto Laish, O poor Anathoth.

Madmenah is removed; the inhabitants of Gebim gather themselves to flee.

As yet shall he remain at Nob that day; he shall shake his hand against the mount of the daughter of Zion, the hill of Jerusalem.

Behold, the Lord, the Lord of Hosts shall lop the bough with terror; and the high ones of stature shall be hewn down; and the haughty shall be humbled.

And he shall cut down the thickets of the forests with iron, and Lebanon shall fall by a mighty one.

## 2 Нифай 21

- 1 Мөн Иессийн гол ишнээс салаа урга, мөн нэгэн мөчир түүний үндэснээс ургах болно.
- 2 Мөн Их Эзэний Сүнс түүний дээр байх болно, мэргэн ухаан хийгээд ойлголтын суу билиг, хүч чадал ба зөвлөлийн суу билиг, мэдлэг хийгээд Их Эзэнээс айх айдсын тэрхүү суу билиг болой;
- 3 Мөн түүнийг Их Эзэнээс эмээхэд ойлголтыг нь сэргэг болгодог; мөн тэрээр өөрийн мэлмий үзэгдэх байдлаар аливааг үл шүүнэ, бас өөрийн чихэнд сонсогдох авиагаар аливааг үл буруушаах буюу.
- 4 Харин зөв шударгаар тэрээр ядуусыг шүүх болно, мөн дэлхийн номхон дөлгөөнчүүдийн төлөө шударга журмын дагуу зэмлэл хүлээлгэх бөлгөө; мөн тэр үгэн саваагаараа энэ дэлхийг цохиж, мөн уруулаасаа гарах амьсгаагаар тэрээр ёс бусыг үйлдэгсдийг егүүтгэх болно.
- 5 Мөн зөв шударга байдал түүний хэвлийн тус бүслэгдсэн болно, мөн итгэл дүүрэн байдал түүний ташаан тус бүслэгдэх болно.
- 6 Чоно хургатай түүнчлэн нэг дор орших болно, мөн ирвэс ишигтэй, мөн тугал болон залуу арслан мөн төл мал хамтдаа зэрэгцэн хэвтэх болно; мөн бяцхан хүүхэд тэднийг хариулах болно.
- 7 Мөн үнээ болон баавгай цуг идэшлэх болно; тэдний үр төл хамтдаа зэрэгцэн хэвтэх болно; мөн арслан шар лугаа адил дэрс идэх болно.
- 8 Мөн хөхүүл хүүхэд загалмайт могойн нүхэнд наадах болно, мөн бойжсон хүүхэд гараа хорт могойн үүрэнд хийх болно.
- 9 Тэд миний бүх ариун ууланд гэмтэхгүй бас устахгүй байх болно, учир нь Их Эзэний мэдлэг дэлхийг тэнгис усаар бүрхсэн лугаа адил дүүргэх болно.
- 10 Мөн тэр өдөр хүмүүсийн далбаа болж зогсох тэрхүү Иессийн үндэс байх болно; үүнийг харийнхан эрэлхийлнэ; мөн түүний амар амгалан сүр жавхлантай байх болно.

## 2 Nephi 21

And there shall come forth a rod out of the stem of Jesse, and a branch shall grow out of his roots.

And the Spirit of the Lord shall rest upon him, the spirit of wisdom and understanding, the spirit of counsel and might, the spirit of knowledge and of the fear of the Lord;

And shall make him of quick understanding in the fear of the Lord; and he shall not judge after the sight of his eyes, neither reprove after the hearing of his ears.

But with righteousness shall he judge the poor, and reprove with equity for the meek of the earth; and he shall smite the earth with the rod of his mouth, and with the breath of his lips shall he slay the wicked.

And righteousness shall be the girdle of his loins, and faithfulness the girdle of his reins.

The wolf also shall dwell with the lamb, and the leopard shall lie down with the kid, and the calf and the young lion and fatling together; and a little child shall lead them.

And the cow and the bear shall feed; their young ones shall lie down together; and the lion shall eat straw like the ox.

And the sucking child shall play on the hole of the asp, and the weaned child shall put his hand on the cockatrice's den.

They shall not hurt nor destroy in all my holy mountain, for the earth shall be full of the knowledge of the Lord, as the waters cover the sea.

And in that day there shall be a root of Jesse, which shall stand for an ensign of the people; to it shall the Gentiles seek; and his rest shall be glorious.



- 11 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр Их Эзэн Ассириас, мөн Египетээс, мөн Пафросоос, мөн Кушаас, мөн Эламаас, мөн Шинараас, мөн Хамафаас, мөн далайн арлуудаас үлдсэн өөрийн хүмүүсийн үлдэгдлийг буцаан авчрахын тулд хоёр дахь удаагаа дахин мутраа хөдөлгөх болно.
- 12 Мөн тэрээр үндэстнүүдэд зориулан далбаа босгож, Израилын цөлөгдөгсөд чуулах болгож, мөн Иудейн тараагдагсдыг энэ дэлхийн дөрвөн зүгээс нэгтгэн цуглуулах болно.
- 13 Ефраимын атаа хорсол түүнчлэн оргүй арилах болно, мөн Иудейн сөргөлдөгчид зайлуулагдах болно; Ефраим Иудейд үл хорсож, мөн Иудей Ефраимыг үл өдөөх болно.
- 14 Харин тэд Филистиний мөрөн дээгүүр өрнө зүг нисэх болно; тэд хамтран дорнын тэднийг тонох болно; тэд өөрсдийн гарыг Едом болон Моабын дээр далайх болно, мөн Аммоны хүүхдүүд тэднийг дуулгавартай дагах болно.
- 15 Мөн Их Эзэн Египетийн тэнгисийн хойгийг бүрмөсөн устгах болно; мөн өөрийн хүчит салхиар мутраа голын дээгүүр сэгсрэх болно, мөн түүнийг долоон салаан дээр нь цохиж, мөн хүмүүсийг хуурай шаахайтай гатлан явах болгоно.
- 16 Мөн Ассираас үлдэх түүний хүмүүсийн үлдэгдэлд зориулагдсан, Египет нутгаас түүний гарч ирсэн тэр өдөр Израилд байсны адил их зам байх болно.

And it shall come to pass in that day that the Lord shall set his hand again the second time to recover the remnant of his people which shall be left, from Assyria, and from Egypt, and from Pathros, and from Cush, and from Elam, and from Shinar, and from Hamath, and from the islands of the sea.

And he shall set up an ensign for the nations, and shall assemble the outcasts of Israel, and gather together the dispersed of Judah from the four corners of the earth.

The envy of Ephraim also shall depart, and the adversaries of Judah shall be cut off; Ephraim shall not envy Judah, and Judah shall not vex Ephraim.

But they shall fly upon the shoulders of the Philistines towards the west; they shall spoil them of the east together; they shall lay their hand upon Edom and Moab; and the children of Ammon shall obey them.

And the Lord shall utterly destroy the tongue of the Egyptian sea; and with his mighty wind he shall shake his hand over the river, and shall smite it in the seven streams, and make men go over dry shod.

And there shall be a highway for the remnant of his people which shall be left, from Assyria, like as it was to Israel in the day that he came up out of the land of Egypt.

## 2 Нифай 22

- 1 Мөн тэр өдөр чи хэлэх болно: Ай Их Эзэн, би таныг магтан дуулна; та надад уурласан гэлээ ч таны уур хилэн тайлагдан цэлмэх буюу, мөн та намайг тайтгаруулах буюу.
- 2 Болгоогтун, Бурхан бол миний аврал; би найдах болно, мөн айх минь үгүй болой; учир нь Их Эзэн Иехова бол миний хүч мөн миний дуу; тэрээр түүнчлэн миний аврал болсон бөлгөө.
- 3 Тиймийн тул, та нар баяр хөөртэйгөөр авралын хурдгуудаас ус татах болно.
- 4 Мөн тэр өдөр та нар хэлнэ: Их Эзэнийг магтан дуулцгаа, түүний нэрийг дуудацгаа, түүний үйлсийг хүмүүсийн дунд тунхаглацгаа, түүний нэр өргөмжлөгдсөнийг дурдан хэлцгээ.
- 5 Их Эзэнд дуулцгаа; учир нь тэрээр онц гайхамшигт зүйлийг хийсэн болой; энэ нь бүх дэлхийд мэдэгдсэн буюу.
- 6 Хашгир мөн бархир, Сионы оршин суугч та; учир нь Израилын Ариун Нэгэн бол та нарын дунд агуу их билээ.

## 2 Nephi 22

And in that day thou shalt say: O Lord, I will praise thee; though thou wast angry with me thine anger is turned away, and thou comfortedst me.

Behold, God is my salvation; I will trust, and not be afraid; for the Lord JEHOVAH is my strength and my song; he also has become my salvation.

Therefore, with joy shall ye draw water out of the wells of salvation.

And in that day shall ye say: Praise the Lord, call upon his name, declare his doings among the people, make mention that his name is exalted.

Sing unto the Lord; for he hath done excellent things; this is known in all the earth.

Cry out and shout, thou inhabitant of Zion; for great is the Holy One of Israel in the midst of thee.

## 2 Нифай 23

- 1 Амосын хүү Исаиагийн харсан Вавилоны тавилан оршвой.
- 2 Та нар тугаа өндөр уулан дээр өргө, тэдэнд дуу хоолойгоо сонордуулцгаа, гараа даллацгаа, тэд язгууртны хаалгаар орж болохын тулд буюу.
- 3 Ариусгагдсан тэдэнд би зарлигласан, би түүнчлэн өөрийн хүчтэнүүдийг дуудсан, тухайлбал миний уур эрхэм дээдэд минь баясах тэдний дээр бус болой.
- 4 Уулан дахь ардын чимээ агуу их хүмүүсийнх лугаа адил, үндэстнүүдийн хаант улсуудын нэгдэн цугларсан нь шуугиант чимээ лугаа адил, Түмний Их Эзэн тулааны цэргүүдээ цуглуулах болно.
- 5 Тэд алсын улсаас, тэнгэрийн хаяанаас ирнэ, тийм ээ, Их Эзэн, мөн түүний зэвүүцлийн зэр зэвсэг, бүх нутгийг устгахаар буюу.
- 6 Та нар орь дуу тавьцгаа, учир нь Их Эзэний өдөр ойрхон байна; энэ нь Бүхнийг Чадагчаас устгал лугаа адил ирэх болно.
- 7 Тиймийн тул хүн бүрийн зүрх алдарч, гар болгон доройтох болно;
- 8 Мөн тэд айх болно; шимшрэл болон харамсал тэднийг эзэмдэн авах болно; тэд бие биесдээ гайхашран байх болно; тэдний царай улалзах дөл мэт байх болно.
- 9 Болгоогтун, Их Эзэний тэр өдөр хэрцгий уур мөн хилэн аль алиныг нь агуулсан харгислал нутгийг эзгүйрүүлэхээр ирэх болно; мөн тэрээр үүний нүгэлтнүүдийг тэндээс гарган устгах болно.
- 10 Өөрөөр хэлбэл тэнгэрийн эрхсүүд мөн одны ордууд гэрлээ өгөхгүй байх болно; нар мандах хэдий ч харанхуйлагдах болно, мөн сар гэрлээ туяаруулахгүй болно.
- 11 Мөн би дэлхийг нүгэл хилэнцийнх нь учир мөн ёсон бусыг үйлдэгчдийг алдсынх нь тул шийтгэнэ; бардам нэгний ихэрхэг занг төгсгөл болгоно, мөн харгисын их занг дорд буулгах болно.
- 12 Би хүмүүнийг шижир алтнаас илүү эрхэм; бүр хүмүүнийг Офирын алтан ембүүнээс илүү болгоно.
- 13 Тиймийн тул, Түмний Их Эзэний хилэнд мөн түүний догшин хилэнгийн тэр өдөр би тэнгэрийг сэгсэрч, дэлхий байрнаасаа хөдлөх болно.

## 2 Nephi 23

The burden of Babylon, which Isaiah the son of Amoz did see.

Lift ye up a banner upon the high mountain, exalt the voice unto them, shake the hand, that they may go into the gates of the nobles.

I have commanded my sanctified ones, I have also called my mighty ones, for mine anger is not upon them that rejoice in my highness.

The noise of the multitude in the mountains like as of a great people, a tumultuous noise of the kingdoms of nations gathered together, the Lord of Hosts mustereth the hosts of the battle.

They come from a far country, from the end of heaven, yea, the Lord, and the weapons of his indignation, to destroy the whole land.

Howl ye, for the day of the Lord is at hand; it shall come as a destruction from the Almighty.

Therefore shall all hands be faint, every man's heart shall melt;

And they shall be afraid; pangs and sorrows shall take hold of them; they shall be amazed one at another; their faces shall be as flames.

Behold, the day of the Lord cometh, cruel both with wrath and fierce anger, to lay the land desolate; and he shall destroy the sinners thereof out of it.

For the stars of heaven and the constellations thereof shall not give their light; the sun shall be darkened in his going forth, and the moon shall not cause her light to shine.

And I will punish the world for evil, and the wicked for their iniquity; I will cause the arrogancy of the proud to cease, and will lay down the haughtiness of the terrible.

I will make a man more precious than fine gold; even a man than the golden wedge of Ophir.

Therefore, I will shake the heavens, and the earth shall remove out of her place, in the wrath of the Lord of Hosts, and in the day of his fierce anger.

14 Мөн энэ нь хөөгдсөн гөрөөс лугаа адил байх болно, мөн хариулах хүнгүй хонь мэт байх болно; мөн тэд хүн бүр төрөл төрөгсөддөө эргэж ирнэ, мөн аливаа хүмүүн зугтан нутгаа бараадах болно.

15 Бардам зант тэр болгон нэвт сүлбэгдэх болно; тийм ээ, мөн ёс бусыг үйлдэгсдэд нэгдсэн бүхэн илд мэсээр унагаагдах болно.

16 Тэдний хүүхдүүд түүнчлэн тэдний нүдний өмнө хэдэн хэсэг болон няцлагдах болно; тэдний гэр орон тоногдож мөн эхнэрүүд нь хүчирхийлэгдэх болно.

17 Болгоогтун, мөнгө болон алтыг эс үнэлнэ, бас үүнд үл баясах тэд болох медесчүүдийг тэдний эсрэг би өдөөн хатгах болно.

18 Тэдний нумнууд залуу эрчүүдийг ч түүнчлэн хэдэн хэсэг болгон тасдах болно; мөн тэд хэвлий дэх үрсийг эс өрөвдөх болно; тэдний нүд хүүхдүүдийг ч үл хэлтрүүлэх болно.

19 Мөн Вавилон, хаант улсуудын сүр жавхлан, халдейчуудын гайхамшгийн үзэсгэлэн, Бурхан Содом Гоморра хоёрыг устгасан тэр цагийн адил байх болно.

20 Энэ нь хэзээ ч сууршигчидтай байхгүй, бас үеэс үед орших нь ч үгүй; бас Араб тэнд хэзээ ч майхан босгохгүй; бас хэзээ ч хоньчид тэнд сүргээ хариулахгүй.

21 Харин цөлийн зэрлэг амьтад тэнд хэвтэх болно; мөн тэдний сууцнууд золгүй амьтдаар дүүрэн байх болно; мөн ууль тэнд орших болно, мөн чөтгөрүүд тэнд бүжиглэх болно.

22 Мөн арлын зэрлэг араатнууд тэдний эзгүй сууцанд, мөн тэдний тааламжит ордонд луунууд архирах болно; мөн түүний цаг нь дөхөж, мөн түүний өдөр нь уртасгагдахгүй байх болно. Учир нь би түүнийг хурдан устгана; тийм ээ, өөрөөр хэлбэл би өөрийн хүмүүст нигүүлсэнгүй байна, гэвч ёсон бусыг үйлдэгчид мөхөх болно.

And it shall be as the chased roe, and as a sheep that no man taketh up; and they shall every man turn to his own people, and flee every one into his own land.

Every one that is proud shall be thrust through; yea, and every one that is joined to the wicked shall fall by the sword.

Their children also shall be dashed to pieces before their eyes; their houses shall be spoiled and their wives ravished.

Behold, I will stir up the Medes against them, which shall not regard silver and gold, nor shall they delight in it.

Their bows shall also dash the young men to pieces; and they shall have no pity on the fruit of the womb; their eyes shall not spare children.

And Babylon, the glory of kingdoms, the beauty of the Chaldees' excellency, shall be as when God overthrew Sodom and Gomorrah.

It shall never be inhabited, neither shall it be dwelt in from generation to generation: neither shall the Arabian pitch tent there; neither shall the shepherds make their fold there.

But wild beasts of the desert shall lie there; and their houses shall be full of doleful creatures; and owls shall dwell there, and satyrs shall dance there.

And the wild beasts of the islands shall cry in their desolate houses, and dragons in their pleasant palaces; and her time is near to come, and her day shall not be prolonged. For I will destroy her speedily; yea, for I will be merciful unto my people, but the wicked shall perish.

## 2 Нифай 24

- 1 Өөрөөр хэлбэл Их Эзэн Иаковт нигүүлсэнгүй хандана, мөн Израилыг сонгосон хэвээр, мөн тэдний өөрсдийнх нь нутагт тэднийг суурьшуулах болно; мөн харь этгээдүүд тэдэнтэй нэгтгэгдэх болно, мөн тэд Иаковын угсаанд хавсарга болно.
- 2 Мөн хүмүүс тэднийг авч мөн өөрсдийнх нь газарт тэднийг авчрах болно; тийм ээ, дэлхийн хязгаарт алс холоос; мөн тэд амлалтын нутгууддаа эргэж ирэх болно. Мөн Израилын угсаа тэднийг эзэмших болно, мөн Их Эзэний нутаг зарц шивэгчингүүдийн төлөө байх болно; мөн тэд өөрсдийг нь боолчилж байсан тэднийг олзолж авах болно; мөн тэд өөрсдийн дарлагчдыг эзэгнэн захирах болно.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр Их Эзэн харамсал гашуудлаас тань, мөн айдсаас тань, мөн чамайг үйлчлэх болгогдсон тэр хүнд боолчлолоос тань амрах чөлөөг чамд өгөх болно.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр чи Вавилоны хааны эсрэг энэ зүйр үгийг авч, мөн хэлнэ: Дарлагч хэрхэн зогсох болов, алтан хот хэрхэн оршихоо больсон билээ!
- 5 Их Эзэн ёсон бусыг үйлдэгчдийн савааг нь, захирагчдын очирт таягийг хугална.
- 6 Ард олныг уур хилэнгээр үргэлжлүүлэн цохьсон тэрээр, үндэстнүүдийг уураараа захирсан тэрээр хавчигдан зовсон билээ, мөн нэгээхэн ч саад үл болно.
- 7 Бүхэл дэлхий амран, мөн намжина; тэд дуулан аниргүйг эвдэх болно.
- 8 Тийм ээ, шилмүүст модод танд баясна, мөн түүнчлэн Ливаны бүх хуш модод, хэлрүүн: Та дорд унагаагдсанаас хойш нэгээхэн модчин бидний эсрэг ирээгүй болой.
- 9 Таныг ирэхэд тантай уулзахаар там дороос таны тул хөдөлсөн юм; энэ нь таны төлөө үхэгсдийг, дэлхийн удирдагч тэр бүгдийг бусниулна; энэ нь үндэстнүүдийн бүх хаадыг хаан сэнтийнээс босгосон бөлгөө.
- 10 Тэд бүгд ярьж мөн танд хэлнэ: Та бас бидний адил яданги болов уу? Та бидэнтэй ижил болов уу

## 2 Nephi 24

For the Lord will have mercy on Jacob, and will yet choose Israel, and set them in their own land; and the strangers shall be joined with them, and they shall cleave to the house of Jacob.

And the people shall take them and bring them to their place; yea, from far unto the ends of the earth; and they shall return to their lands of promise. And the house of Israel shall possess them, and the land of the Lord shall be for servants and handmaids; and they shall take them captives unto whom they were captives; and they shall rule over their oppressors.

And it shall come to pass in that day that the Lord shall give thee rest, from thy sorrow, and from thy fear, and from the hard bondage wherein thou wast made to serve.

And it shall come to pass in that day, that thou shalt take up this proverb against the king of Babylon, and say: How hath the oppressor ceased, the golden city ceased!

The Lord hath broken the staff of the wicked, the scepters of the rulers.

He who smote the people in wrath with a continual stroke, he that ruled the nations in anger, is persecuted, and none hindereth.

The whole earth is at rest, and is quiet; they break forth into singing.

Yea, the fir trees rejoice at thee, and also the cedars of Lebanon, saying: Since thou art laid down no feller is come up against us.

Hell from beneath is moved for thee to meet thee at thy coming; it stirreth up the dead for thee, even all the chief ones of the earth; it hath raised up from their thrones all the kings of the nations.

All they shall speak and say unto thee: Art thou also become weak as we? Art thou become like unto us?

11 Таны сүр жавхлан доош булшинд авчрагдсан буюу; таны хийлийн дуу чимээ эс сонсогдох буюу; өтнүүд таны дор тархаж, мөн өтнүүд таныг бүрхэх ажгуу.

12 Чи яахан тэнгэрээс унах болов, Ай Люцифер, өглөөний хүү! Үндэстнүүдийг доройтуулсан чи газарт унагаагдах гэж үү!

13 Учир нь чи зүрхэндээ хэлнэ: Би тэнгэр өөд дээшлэх болно, би өөрийн сэнтийг Бурханы оддын дээр өргөмжлөх болно; би хойд зүгт орших, их хуралдайн уулсын дээр түүнчлэн суух болно;

14 Би үүлсийн өндрөөс дээгүүр дээшлэх болно; би Бүхний Дээдийн адил байх болно.

15 Гэвч чи доош тамд бүр нүхний ёроолд авчрагдсан байна.

16 Чамайг харсан тэд чамайг нарийвчлан ажиглах болно, мөн чамайг анхааран үзэж, мөн хэлнэ: энэ нь хаант улсуудыг чичиргэл дэлхийг доргиосон тэр хүн үү

17 Мөн дэлхийг аглаг буйд мэт болгосон, мөн түүний хотуудыг устгасан, мөн хоригдлуудынхаа байрыг эс нээсэн нь энэ үү

18 Үндэстнүүдийн бүх хаад, тийм ээ, тэд бүгд, тэдний нэг бүр нь байрандаа алдар суутайгаар хэвтэх буюу.

19 Гэвч чи жигшүүрт мөчрийн адил, булшнаасаа зайлуулагдсан, алагдсан тэдний үлдэгдэл, илдэнд нэвт сүлбүүлж чулуун нүхэнд орхигдсон тэдний адил буюу; хөлийн дор дэвслэгдсэн хүүр лугаа лугаа адил бөлгөө.

20 Чи булшинд тэдэнтэй нэгдэхгүй байх болно, учир юун гэвэл чи өөрийн нутгийг устгаж мөн өөрийн хүмүүсийг хөнөөсөн билээ; хилэнцийг үйлдэгчдийн үр удам хэзээ ч алдарших нь үгүй.

21 Тэдний эцгүүдийн алдсын учир түүний хүүхдүүдийн хөнөөлтөнд бэлтгэгцгээ, тэд өсөж өндийхгүй, бас нутаг өмчлөхгүй, дэлхийн гадаргууг хотуудаар дүүргэхгүй байхын тулд буюу.

22 Учир нь би тэдний эсрэг босох болно хэмээн, Түмний Их Эзэн өгүүлж, мөн Вавилоноос нэрийг, мөн үлдэгдэл, мөн хүү, мөн үеэлийг тусгаарлана хэмээн Их Эзэн хэлэх болно.

Thy pomp is brought down to the grave; the noise of thy viols is not heard; the worm is spread under thee, and the worms cover thee.

How art thou fallen from heaven, O Lucifer, son of the morning! Art thou cut down to the ground, which did weaken the nations!

For thou hast said in thy heart: I will ascend into heaven, I will exalt my throne above the stars of God; I will sit also upon the mount of the congregation, in the sides of the north;

I will ascend above the heights of the clouds; I will be like the Most High.

Yet thou shalt be brought down to hell, to the sides of the pit.

They that see thee shall narrowly look upon thee, and shall consider thee, and shall say: Is this the man that made the earth to tremble, that did shake kingdoms?

And made the world as a wilderness, and destroyed the cities thereof, and opened not the house of his prisoners?

All the kings of the nations, yea, all of them, lie in glory, every one of them in his own house.

But thou art cast out of thy grave like an abominable branch, and the remnant of those that are slain, thrust through with a sword, that go down to the stones of the pit; as a carcass trodden under feet.

Thou shalt not be joined with them in burial, because thou hast destroyed thy land and slain thy people; the seed of evil-doers shall never be renowned.

Prepare slaughter for his children for the iniquities of their fathers, that they do not rise, nor possess the land, nor fill the face of the world with cities.

For I will rise up against them, saith the Lord of Hosts, and cut off from Babylon the name, and remnant, and son, and nephew, saith the Lord.

23 Би түүнчлэн үүнийг бух шувууны эзэмшил мөн намаг шалбааг болгох болно, мөн би үүнийг устгалын туужуураар шүүрдэнэ хэмээн Түмний Их Эзэн хэлэх бөлгөө.

24 Түмний Их Эзэн тангараглаж, хэлрүүн: Гарцаагүй миний бодсончлон, тийн энэ нь улиран тохиох болно; мөн миний зорьсончлон, тийн байх болно—

25 Би Ассири үндэстний түүнийг нутагтаа авчрах болно, мөн өөрийн уулсын дээр түүнийг хөл дор дэвсэлнэ; чингээд түүний буулга тэднээс мултарч, мөн түүний ачаа тэдний мөрөн дээрээс зайлах болно.

26 Энэ нь бүх дэлхийд зорилго болон тавигдсан тэрхүү зорилго бөлгөө; мөн энэ нь бүх үндэстний дээр сунгагдсан тэрхүү мутар бөлгөө.

27 Учир нь Түмний Их Эзэн зорилго тавьсан, мөн хэн цуцлах билээ? Мөн түүний мутар сунгагдсан, мөн хэн буцааж эргүүлэх билээ

28 Хаан Ахаз нас нөгчсөн тэр жил сайхь тавилан байжээ.

29 Чамайг нам дарах түүний саваа хугарсны учир, бүх Палестин, чи бүү баярла; учир нь могойн үүрнээс наж могой гарч ирэх болно, мөн түүний үр нисдэг галт могой байх болно.

30 Мөн ядуугийн ууган нь тэжээгдэн, мөн тарчиг нэг нь аюулгүй тайван хэвтэх болно; мөн би чиний үндсийг өлсгөлөнгөөр хөнөөнө, мөн тэр нь та нарын үлдэгдлийг хядах болно.

31 Гасал, Ай хаалга; уйл, Ай хот; чи, бүхэл Палестин чи айсандаа арчаагүй болсон; учир нь умардаас утаа суунаглаж, мөн түүний болзсон цагуудад хэн ч ганцаар байхгүй байна.

32 Үндэстнүүдийн элч нар тэгэхэд юу гэж хариулах билээ? Их Эзэн Сионыг үндэслэх болно, мөн түүний хүмүүсийн ядуус үүнд итгэмжлэх болно.

I will also make it a possession for the bittern, and pools of water; and I will sweep it with the besom of destruction, saith the Lord of Hosts.

The Lord of Hosts hath sworn, saying: Surely as I have thought, so shall it come to pass; and as I have purposed, so shall it stand—

That I will bring the Assyrian in my land, and upon my mountains tread him under foot; then shall his yoke depart from off them, and his burden depart from off their shoulders.

This is the purpose that is purposed upon the whole earth; and this is the hand that is stretched out upon all nations.

For the Lord of Hosts hath purposed, and who shall disannul? And his hand is stretched out, and who shall turn it back?

In the year that king Ahaz died was this burden.

Rejoice not thou, whole Palestina, because the rod of him that smote thee is broken; for out of the serpent's root shall come forth a cockatrice, and his fruit shall be a fiery flying serpent.

And the firstborn of the poor shall feed, and the needy shall lie down in safety; and I will kill thy root with famine, and he shall slay thy remnant.

Howl, O gate; cry, O city; thou, whole Palestina, art dissolved; for there shall come from the north a smoke, and none shall be alone in his appointed times.

What shall then answer the messengers of the nations? That the Lord hath founded Zion, and the poor of his people shall trust in it.

## 2 Нифай 25

- 1 Эдүгээ би, Нифай, өөрийн бичсэн, Исаиагийн амаар яригдсан үгсийн талаар зарим зүйлийг ярья. Учир нь болгоогтун, миний хүмүүсийн олонд нь ойлгоход бэрх олон зүйлийг Исаиа ярьсан билээ; учир нь тэд иудейчүүдийн дундах бошиглолын арга ухааны талаар мэдэх нь үгүй.
- 2 Учир нь би, Нифай, тэдэнд иудейчүүдийн заншлын талаар олон зүйлийг заасан минь үгүй; учир нь тэдний ажлууд харанхуйн ажлууд байв, мөн тэдний үйлүүд жигшүүрт үйлүүд байсан бөлгөө.
- 3 Иймийн тул, би өөрийн хүмүүст, миний бичих эдгээр зүйлийг цаашид хүлээн авах тэд бүгдэд бичье, Бурханы ярьсан үгийн дагуу, түүний шүүлтүүд, бүх үндэстнүүдийн дээр ирэхийг тэд мэдэж болохын тулд болой.
- 4 Иймийн тул, анхаарцгаа, Ай хүмүүс минь, Израилын угсааных болох та нар, мөн миний үгсийг чих тавин сонсоцгоо; өөрөөр хэлбэл Исаиагийн үгс та нарт тодорхой бус учир, хэдий тийм боловч тэдгээр нь бошиглолын суу билгээр дүүргэгдсэн тэд бүгдэд тодорхой юм. Харин би та нарт өөрт буй суу билгийн дагуу бошиглолыг өгье; иймийн тул би Иерусалимаас эцэгтэйгээ гарч ирсэн тэр цагаас надад байсан тодорхой байдлын дагуу бошиглох болно; учир нь болгоогтун, тэд сурч болохын тулд, өөрийн хүмүүст тодорхойгоор ярихад бодгаль минь баяснам.
- 5 Тийм ээ, мөн бодгаль минь Исаиагийн үгсэд баяснам, учир нь би Иерусалимаас гарч ирсэн, мөн нүд минь иудейчүүдийн зүйлийг харсан, бас иудейчүүд бошиглогчдын зүйлийг ойлгодгийг би мэднэ, мөн тэд иудейчүүдийн зүйлүүдийн дагуу заалгаснаас бусдаар бол иудейчүүдэд яригдсан тэдгээр зүйлийг тэдний адил ойлгох хүмүүс өөр үгүй билээ.

## 2 Nephi 25

Now I, Nephi, do speak somewhat concerning the words which I have written, which have been spoken by the mouth of Isaiah. For behold, Isaiah spake many things which were hard for many of my people to understand; for they know not concerning the manner of prophesying among the Jews.

For I, Nephi, have not taught them many things concerning the manner of the Jews; for their works were works of darkness, and their doings were doings of abominations.

Wherefore, I write unto my people, unto all those that shall receive hereafter these things which I write, that they may know the judgments of God, that they come upon all nations, according to the word which he hath spoken.

Wherefore, hearken, O my people, which are of the house of Israel, and give ear unto my words; for because the words of Isaiah are not plain unto you, nevertheless they are plain unto all those that are filled with the spirit of prophecy. But I give unto you a prophecy, according to the spirit which is in me; wherefore I shall prophesy according to the plainness which hath been with me from the time that I came out from Jerusalem with my father; for behold, my soul delighteth in plainness unto my people, that they may learn.

Yea, and my soul delighteth in the words of Isaiah, for I came out from Jerusalem, and mine eyes hath beheld the things of the Jews, and I know that the Jews do understand the things of the prophets, and there is none other people that understand the things which were spoken unto the Jews like unto them, save it be that they are taught after the manner of the things of the Jews.



- 6 Гэвч болгоогтун, би, Нифай, Иудейчүүдийн аргын дагуу хүүхдүүддээ заасан нь үгүй; гэвч болгоогтун, би өөрийн биеэр, Иерусалимд оршин байсан бөлгөө, иймийн тул би эргэн тойрны нутгийнх нь талаар мэднэ; мөн Исаиагийн ярьсан тэдгээр бүгдийн дагуу, хүүхдүүддээ иудейчүүдийн дунд улиран тохиох Бурханы шүүлтүүдийн талаар би хүүхдүүддээ дурдсан, мөн би тэдгээрийг үл бичих болой.
- 7 Гэвч болгоогтун, би өөрийн, энгийн тодорхой байдлын дагуу өөрийнхөө бошиглолыг үргэлжлүүлэе; ямар ч хүн алдах боломжгүйг мэдэх тэр байдлын тухай; гэсэн хэдий ч, Исаиагийн бошиглолууд биелэгдэх тэрхүү өдрүүдэд хүмүүс гарцаагүй мэднэ, тэдгээр нь улиран тохиох тэрхүү цагуудад болой.
- 8 Иймийн тул, тэдгээр нь хүмүүний үрсэд чухал билээ, мөн тэдгээрийг тийм бус хэмээн бодох тэдэнд, ялангуяа тэдэнд би ярина, мөн үгсээ өөрийнхөө хүмүүсээр хязгаарлая; өөрөөр хэлбэл тэдгээр нь эцсийн өдрүүдэд тэдэнд агуу чухал зүйл байх болно гэдгийг би мэднэ; учир нь тэр өдөр тэд тэдгээрийг ойлгох болно; иймийн тул, тэдний тусын тулд би тэдгээрийг бичиглэсэн бөлгөө.
- 9 Мөн алдсын учир иудейчүүдийн дунд нэгэн үеийнхэн устгагдсаны адил, тэрчлэн тэд үеэс үед алдсуудынхаа дагуу устгагдсаар байгаа буюу; мөн тэдэнд Их Эзэний бошиглогчдоор угтан хэлэгдээгүй бол тэднээс нэгээхэн нь ч устгагдсан нь хэзээ ч үгүй билээ.
- 10 Иймийн тул, миний эцэг Иерусалимыг орхисон тэр даруй, тэдний дээр ирэх ёстой устгалын талаар тэдэнд хэлэгдсэн билээ; гэсэн хэдий ч, тэд зүрх сэтгэлээ хатууруулсан; мөн миний бошиглолын дагуу Вавилонд боолчлолд аваачигдсан тэднээс бусад нь устгагдсан болой.
- 11 Мөн эдүгээ надад орших суу билгийн учир би үүнийг ярьж байна. Мөн тэд аваачигдсан гэлээ ч тэд дахин эргэж ирнэ, мөн Иерусалимын нутгийг эзэмших болно; иймийн тул, тэд өвлөсөн нутагтаа сэргээгдэх болно.

But behold, I, Nephi, have not taught my children after the manner of the Jews; but behold, I, of myself, have dwelt at Jerusalem, wherefore I know concerning the regions round about; and I have made mention unto my children concerning the judgments of God, which hath come to pass among the Jews, unto my children, according to all that which Isaiah hath spoken, and I do not write them.

But behold, I proceed with mine own prophecy, according to my plainness; in the which I know that no man can err; nevertheless, in the days that the prophecies of Isaiah shall be fulfilled men shall know of a surety, at the times when they shall come to pass.

Wherefore, they are of worth unto the children of men, and he that supposeth that they are not, unto them will I speak particularly, and confine the words unto mine own people; for I know that they shall be of great worth unto them in the last days; for in that day shall they understand them; wherefore, for their good have I written them.

And as one generation hath been destroyed among the Jews because of iniquity, even so have they been destroyed from generation to generation according to their iniquities; and never hath any of them been destroyed save it were foretold them by the prophets of the Lord.

Wherefore, it hath been told them concerning the destruction which should come upon them, immediately after my father left Jerusalem; nevertheless, they hardened their hearts; and according to my prophecy they have been destroyed, save it be those which are carried away captive into Babylon.

And now this I speak because of the spirit which is in me. And notwithstanding they have been carried away they shall return again, and possess the land of Jerusalem; wherefore, they shall be restored again to the land of their inheritance.

- 12 Гэвч, болгоогтун, дайнууд мөн дайны цуурхлууд байх болно; мөн Эцэгийн Төрсөн Ганцын, тийм ээ, бүр тэнгэр болон газрын Эцэг, өөрийгөө тэдэнд бие маханбодид үзүүлэх тэр өдөр ирэхэд, болгоогтун, тэд түүнийг эсэргүүцэх болно, учир юун гэвэл тэдний алдсуудын, мөн тэдний зүрх сэтгэлийн хатуугийн, мөн тэдний зөрүүдийн улмаас бөлгөө.
- 13 Болгоогтун, тэд түүнийг цовдлох болно; мөн тэрээр хадан булшинд гурав хоногийн турш хэвтүүлэгдсэний дараа тэр жигүүрэндээ анагаах чадлыг эзэмдэн нас барагсдаас босох болно; мөн түүний алдар сууд итгэх хэн боловч бүгд Бурханы хаант улсад аврагдах болно. Иймийн тул, түүний талаар бошиглоход бодгаль минь баясна, учир нь би түүний өдрийг харсан, мөн зүрх сэтгэл минь түүний ариун нэрийг алдаршуулна.
- 14 Мөн болгоогтун улиран тохиох дор Мессиа нас барагсдаас босч, мөн өөрийгөө өөрийн хүмүүст, түүний нэрэнд итгэх тэр болгонд үзүүлсний дараа, болгоогтун Иерусалим дахин устгагдах болно; өөрөөр хэлбэл Бурханы эсрэг мөн түүний сүмийн хүмүүсийн эсрэг тулалдах тэдэнд халаг.
- 15 Иймийн тул, иудейчүүд бүх үндэстнүүдийн дунд тараагдах болно; тийм ээ, мөн түүнчлэн Вавилон устгагдах болно; иймийн тул, иудейчүүд бусад үндэстнүүдээр тараагдах болно.
- 16 Мөн тэд тараагдаж, мөн Их Эзэн Бурхан тэднийг бусад үндэстнүүдээр олон үеийн турш цээрлүүлсний дараа, тийм ээ, бүр үеэс үед, тэд Бурханы Хүү, Христэд мөн бүх хүн төрөлхтний төлөөх хязгааргүй тэрхүү цагаатгалд итгэхийг ятгуулах тэр үеийг хүртэл буюу—мөн тэд сэвгүй зүрх сэтгэл мөн цэвэр гартайгаар, Христэд итгэн мөн түүний нэрээр Эцэгийг бишрэн шүтэж, мөн өөр ямар ч Мессиаг харуулдан хүлээхгүй тэрхүү өдөр ирэхэд, чингээд, тэр цагт, тэд эдгээр зүйлүүдэд итгэх нь зүйд нийцэх тэрхүү өдөр ирэх бөлгөө.
- 17 Мөн Их Эзэн төөрөлдсөн мөн унасан байдлаас нь өөрийн хүмүүсийг сэргээхээр хоёр дахь удаагаа мутраа дахин хөдөлгөх болно. Иймийн тул, тэрээр хүмүүний үрсийн дунд ер бусын ажил мөн гайхамшигийг үйлдэхээ үргэлжлүүлэх болно.

But, behold, they shall have wars, and rumors of wars; and when the day cometh that the Only Begotten of the Father, yea, even the Father of heaven and of earth, shall manifest himself unto them in the flesh, behold, they will reject him, because of their iniquities, and the hardness of their hearts, and the stiffness of their necks.

Behold, they will crucify him; and after he is laid in a sepulchre for the space of three days he shall rise from the dead, with healing in his wings; and all those who shall believe on his name shall be saved in the kingdom of God. Wherefore, my soul delighteth to prophesy concerning him, for I have seen his day, and my heart doth magnify his holy name.

And behold it shall come to pass that after the Messiah hath risen from the dead, and hath manifested himself unto his people, unto as many as will believe on his name, behold, Jerusalem shall be destroyed again; for wo unto them that fight against God and the people of his church.

Wherefore, the Jews shall be scattered among all nations; yea, and also Babylon shall be destroyed; wherefore, the Jews shall be scattered by other nations.

And after they have been scattered, and the Lord God hath scourged them by other nations for the space of many generations, yea, even down from generation to generation until they shall be persuaded to believe in Christ, the Son of God, and the atonement, which is infinite for all mankind—and when that day shall come that they shall believe in Christ, and worship the Father in his name, with pure hearts and clean hands, and look not forward any more for another Messiah, then, at that time, the day will come that it must needs be expedient that they should believe these things.

And the Lord will set his hand again the second time to restore his people from their lost and fallen state. Wherefore, he will proceed to do a marvelous work and a wonder among the children of men.

18 Иймийн тул, тэрээр өөрийн үгсийг тэдэнд авчрах болно, тэднийг эцсийн өдөр шүүх тэр үгсийг, учир нь тэднээр эсэргүүцэгдсэн үнэн Мессиад тэднийг итгүүлэх зорилгын учир тэдэнд тэдгээр нь өгөгдөх болно; мөн хүмүүсийг залилах тэр хуурамч Мессиагаас өөр ямар нь ч ирэхгүй учир, өөр Мессиа ирэхийг тэд харуулах хэрэггүй хэмээн тэдэнд итгүүлэхийн тулд бөлгөө; учир нь бошиглогчдоор яригдсан ганцхан Мессиа буй, мөн Мессиа нь иудейчүүдээр эсэргүүцэгдэх тэр бөлгөө.

19 Өөрөөр хэлбэл бошиглогчдын үгсийн дагуу, миний эцэг Иерусалимыг орхисон цагаас зургаан зуун жилийн тэртээ Мессиа ирнэ; мөн бошиглогчдын үгсийн мөн түүнчлэн Бурханы тэнгэр элчийн үгийн дагуу, түүний нэрийг Бурханы Хүү, Есүс Христ хэмээх болно.

20 Мөн эдүгээ, ах дүү нар минь, та нар алдаа гаргахын аргагүй тодорхойгоор би ярилаа. Мөн Израилыг Египетийн газар нутгаас гаргаж авчирсан, мөн үндэстнүүдийг тэд хорт могойнуудад хазуулсны нь дараа, хэрэв тэдний өмнө өргөсөн тэр могойг зовхи өргөн тэд харах аваас анагаагдах хүчийг Мосед өгсөн, мөн түүнчлэн тэрээр хэдыг хагалан ус гаргах хүчийг түүнд өгсөн Их Эзэн Бурхан амьдын адил; тийм ээ, болгоогтун, би та нарт хэлнэ, Их Эзэн Бурхан амьдын адил, эдгээр зүйлүүд үнэний адил, түүгээр хүмүүн аврагдаж чадах миний ярьсан тэр Есүс Христийнхээс өөр нэр тэнгэрийн дор өгөгдөөгүй болой.

21 Иймийн тул, миний бичсэн эдгээр зүйлүүд хадгалагдан бас хамгаалагдана, мөн миний үр удамд, үеэс үед гардуулагдах болно хэмээн иймийн улмаас Их Эзэн Бурхан надад амласан юм, түүний үр удам энэ дэлхий тогтнож байх цагт хэзээ ч үл эрсдэнэ гэсэн уг амлалт Иосефт биелэгдэж болохын тулд буюу.

22 Иймийн тул, эдгээр зүйлүүд энэ дэлхий тогтнож байх цагт үеэс үед дамжин явах болно; мөн тэдгээр нь Бурханы таалал мөн хүслийн дагуу явах болно; мөн тэдгээрийг эзэмших үндэстнүүд, бичигдэх тэдгээр үгсийн дагуу шүүгдэх болно.

Wherefore, he shall bring forth his words unto them, which words shall judge them at the last day, for they shall be given them for the purpose of convincing them of the true Messiah, who was rejected by them; and unto the convincing of them that they need not look forward any more for a Messiah to come, for there should not any come, save it should be a false Messiah which should deceive the people; for there is save one Messiah spoken of by the prophets, and that Messiah is he who should be rejected of the Jews.

For according to the words of the prophets, the Messiah cometh in six hundred years from the time that my father left Jerusalem; and according to the words of the prophets, and also the word of the angel of God, his name shall be Jesus Christ, the Son of God.

And now, my brethren, I have spoken plainly that ye cannot err. And as the Lord God liveth that brought Israel up out of the land of Egypt, and gave unto Moses power that he should heal the nations after they had been bitten by the poisonous serpents, if they would cast their eyes unto the serpent which he did raise up before them, and also gave him power that he should smite the rock and the water should come forth; yea, behold I say unto you, that as these things are true, and as the Lord God liveth, there is none other name given under heaven save it be this Jesus Christ, of which I have spoken, whereby man can be saved.

Wherefore, for this cause hath the Lord God promised unto me that these things which I write shall be kept and preserved, and handed down unto my seed, from generation to generation, that the promise may be fulfilled unto Joseph, that his seed should never perish as long as the earth should stand.

Wherefore, these things shall go from generation to generation as long as the earth shall stand; and they shall go according to the will and pleasure of God; and the nations who shall possess them shall be judged of them according to the words which are written.

- 23 Учир нь бид Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг хүүхдүүддээ мөн түүнчлэн ах дүүстээ ятгахын тулд бичихээр хичээнгүйлэн хөдөлмөрлөв; учир нь бид ач ивээлээр л бид аврагдана гэдгийг мэднэ, бидний хийж чадах бүхний дараа буюу.
- 24 Мөн, бид Христэд итгэдэг хэдий ч, бид Мосегийн хуулийг дагадаг, мөн бат итгэлтэйгээр Христийг харуулдана, уг хууль гүйцэлдэх хүртэл бөлгөө.
- 25 Өөрөөр хэлбэл, ийм зорилгоор уг хууль өгөгдсөн юм; иймийн тул уг хууль бидэнд үхмэл болсон, мөн итгэлийнхээ учир бид Христээр амьд болгогддог; гэсэн ч зарлигуудын учир бид уг хуулийг дагадаг бөлгөө.
- 26 Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглоуудынхаа дагуу бичдэг болой.
- 27 Иймийн тул, бидний хүүхдүүд уг хуулийн үхмэлийг мэдэж болно хэмээн бид уг хуулийн талаар ярьдаг; мөн тэд, уг хуулийн үхмэлийг мэдсэнээрээ, Христэд байх тэрхүү амьдралыг харуулдаж болох ажгуу, мөн уг хууль ямар зорилгын тулд өгөгдсөнийг мэдэх бөлгөө. Мөн Христээр уг хууль биелэгдсэний дараа, хууль цуцлагдах ёстой байхад тэд зүрх сэтгэлээ түүний эсрэг хатууруулах хэрэггүйг мэдэх болно.
- 28 Мөн эдүгээ болгоогтун, хүмүүс минь, та нар гэжүүд хүмүүс; иймийн тул, та нар буруугаар ойлгож чадахааргүй тодорхойгоор би та нарт ярьсан. Мөн миний ярьсан үгс та нарын эсрэг гэрчлэл болон зогсох болно; учир нь тэд ямар ч хүнд зөв замыг заахад хангалттай; өөрөөр хэлбэл зөв зам гэдэг нь Христэд итгэх мөн түүнийг үл үгүйсгэх юм; учир нь түүнийг үгүйсгэснээр та нар түүнчлэн бошиглогчид мөн хуулийг үгүйсгэх ажгуу.

For we labor diligently to write, to persuade our children, and also our brethren, to believe in Christ, and to be reconciled to God; for we know that it is by grace that we are saved, after all we can do.

And, notwithstanding we believe in Christ, we keep the law of Moses, and look forward with steadfastness unto Christ, until the law shall be fulfilled.

For, for this end was the law given; wherefore the law hath become dead unto us, and we are made alive in Christ because of our faith; yet we keep the law because of the commandments.

And we talk of Christ, we rejoice in Christ, we preach of Christ, we prophesy of Christ, and we write according to our prophecies, that our children may know to what source they may look for a remission of their sins.

Wherefore, we speak concerning the law that our children may know the deadness of the law; and they, by knowing the deadness of the law, may look forward unto that life which is in Christ, and know for what end the law was given. And after the law is fulfilled in Christ, that they need not harden their hearts against him when the law ought to be done away.

And now behold, my people, ye are a stiffnecked people; wherefore, I have spoken plainly unto you, that ye cannot misunderstand. And the words which I have spoken shall stand as a testimony against you; for they are sufficient to teach any man the right way; for the right way is to believe in Christ and deny him not; for by denying him ye also deny the prophets and the law.

29 Мөн эдүгээ болгоогтун, зөв зам нь Христэд итгэх, мөн түүнийг эс үгүйсгэх гэдгийг; мөн Христ бол Израилын Ариун Нэгэн гэдгийг би та нарт хэлнэ; иймийн тул та нар түүний өмнө доош бөхийж, мөн түүнийг өөрсдийн бүхий л хүчин чадал, оюун, мөн чадлаараа, мөн өөрийн бүхэл бодгалиар бишрэн шүтэх ёстой; мөн хэрэв та нар үүнийг хийх аваас явч зайлуулагдах учиргүй.

30 Мөн, энэ нь зайлшгүйн хэрээр, та нар Мосед өгөгдсөн тэрхүү хуулийг биелэгдэх хүртэл Бурханы ёслолууд хийгээд үйлүүдийг сахих ёстой.

And now behold, I say unto you that the right way is to believe in Christ, and deny him not; and Christ is the Holy One of Israel; wherefore ye must bow down before him, and worship him with all your might, mind, and strength, and your whole soul; and if ye do this ye shall in nowise be cast out.

And, inasmuch as it shall be expedient, ye must keep the performances and ordinances of God until the law shall be fulfilled which was given unto Moses.

## 2 Нифай 26

- 1 Мөн Христ нас барагсдаас боссоныхоо дараа тэрээр өөрийгөө та нарт үзүүлэх болно, хүүхдүүд минь, мөн хайрт ах дүү нар минь; мөн түүний та нарт ярих үгс нь та нарын дагах тэрхүү хууль байх болно.
- 2 Учир нь болгоогтун, олон үе улиран өнгөрч, мөн миний хүмүүсийн дунд их дайн мөн тэмцлүүд болохыг би болгоосон хэмээн би та нарт хэлнэ.
- 3 Мөн Мессиаг ирсний дараа миний хүмүүст түүний төрөх, мөн түүнчлэн түүний үхлийн мөн амилалтын тэмдгүүд өгөгдөх болно; мөн тэр өдөр ёс бусыг үйлдэгчдэд агуу болоод аймшигт байна, учир нь тэд эрсдэх болно; мөн тэд бошиглогчид, мөн гэгээнтнүүдийг зайлуулж мөн тэдний зүг чулуу нүүлгэж, мөн тэднийг хөнөөдгийн учир тэд мөхөх болно; иймийн тул гэгээнтнүүдийн цусны хашгирах дуу тэдний эсрэг газар дэлхийгээс дээш Бурханд хүрэх болно.
- 4 Иймийн тул, бардам, мөн ёсон бусаар үйлдэгч тэд бүгдийг, Түмний Их Эзэний хэлсэнчлэн, тэднийг шатаах тэр өдөр ирнэ, учир нь тэд талбайд хаягдсан сүрэл лугаа адил байх болно.
- 5 Мөн бошиглогчдыг, мөн гэгээнтнүүдийг хөнөөдөг тэд, газрын гүн нь тэднийг залгих болно хэмээн Түмний Их Эзэн хэлнэ; мөн уулс тэднийг дарна, мөн хар салхи тэднийг хийсгэн одно, мөн барилгууд тэдний дээр унаж мөн тэднийг жижиг хэсгүүд болгон няцалж мөн нунтаг болгон нүдэх болно.
- 6 Мөн аянга, мөн цахилгаан, мөн газар хөдлөлт, мөн бүх төрлийн устгалуудаар тэд дайлагдах болно, учир нь Их Эзэний хилэнгийн гал тэдний эсрэг дүрэлзэж байх болно, мөн тэд талбайд хаягдсан сүрэл мэт байх болно, мөн ирэх тэр өдөр тэднийг шатаана хэмээн Түмний Их Эзэн хэлсэн буюу.
- 7 Өөрийн хүмүүсийн хөнөөгдсөн алдагдлын учир зүрх сэтгэлийн минь тарчлал бас, Ай шаналал! Учир нь би, Нифай, үүнийг харсан, мөн энэ нь Их Эзэний дэргэд намайг бараг л сүйтгэх шахав; гэвч өөрийн Бурханд би: Таны замууд шударга хэмээн залбирах ёстой.

## 2 Nephi 26

And after Christ shall have risen from the dead he shall show himself unto you, my children, and my beloved brethren; and the words which he shall speak unto you shall be the law which ye shall do.

For behold, I say unto you that I have beheld that many generations shall pass away, and there shall be great wars and contentions among my people.

And after the Messiah shall come there shall be signs given unto my people of his birth, and also of his death and resurrection; and great and terrible shall that day be unto the wicked, for they shall perish; and they perish because they cast out the prophets, and the saints, and stone them, and slay them; wherefore the cry of the blood of the saints shall ascend up to God from the ground against them.

Wherefore, all those who are proud, and that do wickedly, the day that cometh shall burn them up, saith the Lord of Hosts, for they shall be as stubble.

And they that kill the prophets, and the saints, the depths of the earth shall swallow them up, saith the Lord of Hosts; and mountains shall cover them, and whirlwinds shall carry them away, and buildings shall fall upon them and crush them to pieces and grind them to powder.

And they shall be visited with thunderings, and lightnings, and earthquakes, and all manner of destructions, for the fire of the anger of the Lord shall be kindled against them, and they shall be as stubble, and the day that cometh shall consume them, saith the Lord of Hosts.

O the pain, and the anguish of my soul for the loss of the slain of my people! For I, Nephi, have seen it, and it well nigh consumeth me before the presence of the Lord; but I must cry unto my God: Thy ways are just.

- 8 Гэвч болгоогтун, бошиглогчдын үгсийг анхааран сонсох, мөн тэднийг үл устгах, харин бүх хавчлагыг үл хайхран, өгөгдсөн тэмдгүүдийн учир гуйвшгүйгээр Христийг харуулдан хүлээх зөв шударгыг үйлдэгчид—болгоогтун, тэд бол мөхөх нь үгүй тэд бол.
- 9 Харин Зөв Шударгын Хүү тэдэн дээр хүрч ирэх болно; мөн тэрээр тэднийг анагаах болно, мөн тэд түүнтэй гурван үе улиран өнгөртөл амар амгалан байх болно, мөн дөрөв дэх үеийнхнээс олон нь зөв шударгаар улирч одох болно.
- 10 Мөн эдгээр зүйлүүд улирч өнгөрсний дараа миний хүмүүсийн дээр устгал хурдан ирнэ; өөрөөр хэлбэл, зүрх сэтгэл минь шаналах хэдий ч, би үүнийг харсан; иймийн тул, энэ нь улиран тохиох болно гэдгийг би мэднэ; мөн тэд өөрсдийгөө хоосон зүйлээр арилжина; өөрөөр хэлбэл, өөрсдийн их зан мөн өөрсдийн мунхаглалын шагнал болгож тэд устгалыг хадаж авах болно; учир нь тэд чөтгөрт бууж өгөн мөн гэрлээс илүүгээр харанхуйн ажлуудыг сонгосон учир, тиймийн тул тэд доош тамд очих ёстой ажгуу.
- 11 Учир нь Их Эзэний Сүнс хүмүүний төлөө үргэлж тэмцэх нь үгүй. Мөн Сүнс хүмүүний төлөө тэмцэхээ болиход чингээд устгал хурдан ирнэ мөн энэ нь бодгалийг минь гонсойлгоно.
- 12 Мөн иудейчүүд Есүс бол туйлын Христ гэдэгт үнэмшүүлэгдэх талаар миний ярьсанчлан, Харийнхан түүнчлэн Есүс бол Христ, Мөнхийн Бурхан гэдэгт үнэмшүүлэгдэх нь гарцаагүй буюу;
- 13 Мөн тэрчлэн Ариун Сүнсний хүчээр тэрээр өөрийгөө түүнд итгэх тэд бүгдэд үзүүлнэ гэдэгт; тийм ээ, үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүс болгонд, хүчит гайхамшгууд, тэмдгүүд мөн ер бусын явдлуудыг хүмүүний үрсийн дунд тэдний итгэлийн дагуу үйлдэнэ гэдэгт бөлгөө.
- 14 Гэвч болгоогтун, би та нарт эцсийн өдрүүдийн талаар бошиглоё; Их Эзэн Бурхан эдгээр зүйлийг хүмүүний үрсэд авчрах тэр өдрүүдийн талаар.

But behold, the righteous that hearken unto the words of the prophets, and destroy them not, but look forward unto Christ with steadfastness for the signs which are given, notwithstanding all persecution—behold, they are they which shall not perish.

But the Son of Righteousness shall appear unto them; and he shall heal them, and they shall have peace with him, until three generations shall have passed away, and many of the fourth generation shall have passed away in righteousness.

And when these things have passed away a speedy destruction cometh unto my people; for, notwithstanding the pains of my soul, I have seen it; wherefore, I know that it shall come to pass; and they sell themselves for naught; for, for the reward of their pride and their foolishness they shall reap destruction; for because they yield unto the devil and choose works of darkness rather than light, therefore they must go down to hell.

For the Spirit of the Lord will not always strive with man. And when the Spirit ceaseth to strive with man then cometh speedy destruction, and this grieveth my soul.

And as I spake concerning the convincing of the Jews, that Jesus is the very Christ, it must needs be that the Gentiles be convinced also that Jesus is the Christ, the Eternal God;

And that he manifesteth himself unto all those who believe in him, by the power of the Holy Ghost; yea, unto every nation, kindred, tongue, and people, working mighty miracles, signs, and wonders, among the children of men according to their faith.

But behold, I prophesy unto you concerning the last days; concerning the days when the Lord God shall bring these things forth unto the children of men.

15 Миний үр удам болон ах нарын маань үр удам итгэлгүйдээ доройтож, мөн харийнханаар цохигдсоны дараа; тийм ээ Их Эзэн Бурхан тэдний эсрэг эргэн тойрон байрлаж, мөн тэдний эсрэг бэхлэлтээр бүслэн сууж, мөн тэдний эсрэг бэхлэлт босгосны дараа; мөн тэд доош дорд шороонд авчрагдсаны дараа, бүр тэднийг үгүй болтол, гэсэн ч зөв шударгыг үйлдэгчдийн үгс бичигдэх болно, мөн итгэлтний залбирлууд сонсогдох болно, мөн итгэлгүйдээ бууран доройтсон тэд мартагдах нь үгүй болой.

16 Учир нь устгагдах тэд газар шорооноос тэдэнд ярих болно, мөн тэдний дуу хоолой газар дороос шивнэх болно, мөн тэдний дуу хоолой сүнс дуудагч лугаа адил байх болно; учир нь тэрээр тэдний талаар шивнэж болохын тулд Их Эзэн Бурхан түүнд хүчийг өгөх болно, бүр энэ нь газрын дороос байсан лугаа адил буюу; мөн тэдний яриа газар шорооноос шивнэх болно.

17 Өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан ийн хэлдэг: Тэдний дунд хийгдэх зүйлийг тэд бичих болно, мөн тэдгээр нь номонд бичигдэн мөн лацдагдах болно, мөн тэдгээрийг итгэлгүйдээ бууран доройтсон тэд эзэмшихгүй, тэд Бурханы зүйлийг устгахыг эрэлхийлэхийн учир болой.

18 Иймийн тул, устгагдсан тэд хурднаар устгагдсаны учир юм; мөн аймшигт тэдний хүмүүс улирч гээгдэх будааны хальс хог мэт байх болно—тийм ээ, Их Эзэн Бурхан ийн хэлнэ: Энэ нь агшин зуур, гэнэтхэн байх болно—

19 Мөнхүү улиран тохиох дор, тэдгээр итгэлгүйдээ бууран доройтоггод харийнханы гарт цохигдох болно.

20 Мөн харийнхан өөрсдийнхөө нүдний бардамналд хөөрсөн, мөн бүдэрсэн, тэдний тээглэх чулууны ихийн учир, тиймээс тэд олон сүм босгосон буюу; гэсэн хэдий ч тэд Бурханы хүч мөн гайхамшигийг дорд үзэн, мөн тэд хөрөнгө хурааж мөн ядуугийн нүүрийг няцалж болохын тулд өөрсөддөө өөрсдийн мэргэн ухаан мөн өөрсдийн суралцсанаа номлох болно.

21 Мөн атаа жетөө, мөн хэрүүл маргаан, мөн өшөө хорсол үүсгэх тэдгээр олон сүм босгогдсон билээ.

After my seed and the seed of my brethren shall have dwindled in unbelief, and shall have been smitten by the Gentiles; yea, after the Lord God shall have camped against them round about, and shall have laid siege against them with a mount, and raised forts against them; and after they shall have been brought down low in the dust, even that they are not, yet the words of the righteous shall be written, and the prayers of the faithful shall be heard, and all those who have dwindled in unbelief shall not be forgotten.

For those who shall be destroyed shall speak unto them out of the ground, and their speech shall be low out of the dust, and their voice shall be as one that hath a familiar spirit; for the Lord God will give unto him power, that he may whisper concerning them, even as it were out of the ground; and their speech shall whisper out of the dust.

For thus saith the Lord God: They shall write the things which shall be done among them, and they shall be written and sealed up in a book, and those who have dwindled in unbelief shall not have them, for they seek to destroy the things of God.

Wherefore, as those who have been destroyed have been destroyed speedily; and the multitude of their terrible ones shall be as chaff that passeth away—yea, thus saith the Lord God: It shall be at an instant, suddenly—

And it shall come to pass, that those who have dwindled in unbelief shall be smitten by the hand of the Gentiles.

And the Gentiles are lifted up in the pride of their eyes, and have stumbled, because of the greatness of their stumbling block, that they have built up many churches; nevertheless, they put down the power and miracles of God, and preach up unto themselves their own wisdom and their own learning, that they may get gain and grind upon the face of the poor.

And there are many churches built up which cause envyings, and strifes, and malice.



- 22 Мөн түүнчлэн нууц холбоонууд, бүр хуучин цагт байсны адил, чөтгөрийн холбоонуудын дагуу байна, учир нь тэрээр эдгээр зүйлүүдийн үндэслэгч юм; тийм ээ, аллагын мөн харанхуйн ажлуудын үндэслэгч бөлгөө; тийм ээ, мөн тэрээр тэднийг бөх олсоор үүрд хүлэх хүртлээ, тэднийг маалинган оосроор хүзүүгээр нь оосорлон удирдах бөлгөө.
- 23 Учир нь болгоогтун, хайрт ах дүү нар минь, Их Эзэн Бурхан харанхуйд ажилладаггүйг би та нарт хэлье.
- 24 Тэрээр энэ дэлхийн төлөө бус аваас ямар ч зүйлийг эс хийх авай; учир нь тэрээр дэлхийг хайрладаг, бүр тэрээр бүх хүмүүнийг өөртөө ойртуулж болохын тулд тэр амиа өгсөн болой. Иймийн тул, тэрээр хэнд ч өөрийн авралыг бүү хүрт хэмээн үл зарлигладаг билээ.
- 25 Болгоогтун, тэрээр нэгээхэнд ч болов хэлрүүн: Надаас холд хэмээн айлдах уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; харин тэр хэлдэг: Дэлхийн хязгаарууд та нар бүгд надад ирэгтүн, мөнгөгүйгээр мөн төлбөргүйгээр, сүү болон бал худалдаж авцгаа.
- 26 Болгоогтун, тэд синагогоос гарч холдохыг, эсвээс шүтлэгийн өргөөнөөс гарахыг нэгээхэнд боловч тэрээр зарлигласан уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй.
- 27 Тэрээр өөрийн авралаас тэд хүртэх ёсгүй хэмээн нэгээхэнд боловч зарлигласан уу? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; харин тэрээр үүнийг бүх хүмүүний тулд үнэгүйгээр өгсөн билээ; мөн тэд наманчлахыг бүхий л хүмүүнд ятгах ёстойг тэрээр өөрийн хүмүүст зарлигласан билээ.
- 28 Болгоогтун, тэд өөрийнх нь сайн сайхнаас хүртэх ёсгүй хэмээн нэгээхэнд боловч Их Эзэн зарлигласан уу? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; харин бүх хүмүүн нэг нь нөгөөгийнхөө адил эрх бүхий бөгөөд нэг нь ч үл хориглогдсон болой.
- 29 Тэрээр санваараар мэргэших нь байх ёсгүй хэмээн зарлигладаг; учир нь, болгоогтун, санваараар мэргэших нь тэд дэлхийгээс баялаг мөн алдрыг хурааж болохын тулд хүмүүний номлолыг номлож өөрсдийгөө хорвоогийн гэрэл болгодог; харин тэд Сионы аз жаргалын төлөө үл эрэлхийлдэг бөлгөө.

And there are also secret combinations, even as in times of old, according to the combinations of the devil, for he is the founder of all these things; yea, the founder of murder, and works of darkness; yea, and he leadeth them by the neck with a flaxen cord, until he bindeth them with his strong cords forever.

For behold, my beloved brethren, I say unto you that the Lord God worketh not in darkness.

He doeth not anything save it be for the benefit of the world; for he loveth the world, even that he layeth down his own life that he may draw all men unto him. Wherefore, he commandeth none that they shall not partake of his salvation.

Behold, doth he cry unto any, saying: Depart from me? Behold, I say unto you, Nay; but he saith: Come unto me all ye ends of the earth, buy milk and honey, without money and without price.

Behold, hath he commanded any that they should depart out of the synagogues, or out of the houses of worship? Behold, I say unto you, Nay.

Hath he commanded any that they should not partake of his salvation? Behold I say unto you, Nay; but he hath given it free for all men; and he hath commanded his people that they should persuade all men to repentance.

Behold, hath the Lord commanded any that they should not partake of his goodness? Behold I say unto you, Nay; but all men are privileged the one like unto the other, and none are forbidden.

He commandeth that there shall be no priestcrafts; for, behold, priestcrafts are that men preach and set themselves up for a light unto the world, that they may get gain and praise of the world; but they seek not the welfare of Zion.

- 30 Болгоогтун, Их Эзэн энэ зүйлийг хориглосон билээ; иймийн тул, Их Эзэн Бурхан хүмүүнд энэрэл, хайр гэгдэх тэрхүү энэрэл байх ёстой хэмээх зарлиг өгсөн билээ. Мөн тэдэнд энэрэл байхгүй бол тэд юу ч биш болой. Иймийн тул, хэрэв тэдэнд энэрэл буй аваас тэд Сионд хөдөлмөрлөгч эрсдэхийг үл тэвчих буйза.
- 31 Гэвч Сионы хөдөлмөрлөгч Сионы төлөө хөдөлмөрлөх болно; учир нь хэрэв тэд мөнгөний төлөө хөдөлмөрлөх аваас тэд эрсдэх болно.
- 32 Мөн түүнчлэн, хүмүүн нь алах ёсгүй; тэд худал хэлэх ёсгүй; тэд хулгайлах ёсгүй; тэд Их Эзэн Бурханыхаа нэрийг хий хоосон хэрэглэх ёсгүй; тэд атаархах ёсгүй; тэд хонзогнох ёсгүй; тэд өөр хоорондоо зөрчилдөх ёсгүй; тэд садар самууныг үйлдэх ёсгүй; мөн тэд эдгээр зүйлүүдийн алийг нь ч гэсэн хийх ёсгүй хэмээн Их Эзэн Бурхан зарлигласан ажгуу; учир нь эдгээрийг хийх хэн ч гэсэн эрсдэх болно.
- 33 Учир нь эдгээр алдсуудын нэгээхэн нь ч Их Эзэнээс ирдэггүй; өөрөөр хэлбэл тэрээр хүмүүний үрсийн дунд сайн болох түүнийг л хийдэг; мөн тэрээр хүмүүний үрсэд тодорхойгоос бусдаар юуг ч үл хийнэ; мөн тэрээр тэднийг бүгд өөрт нь ирж мөн өөрийнх нь сайн сайхныг хүртэхийг урьдаг; мөн тэрээр хар ба цагаан, боол ба чөлөөт, эр болон эм, түүнд ирэх хэнээс боловч үл татгалздаг; мөн тэрээр үнэн Бурханыг мэддэггүй хүмүүсийг ч санадаг; мөн Бурханд бүгд адил, Иудей болон Харь аль аль нь буюу.

Behold, the Lord hath forbidden this thing; wherefore, the Lord God hath given a commandment that all men should have charity, which charity is love. And except they should have charity they were nothing. Wherefore, if they should have charity they would not suffer the laborer in Zion to perish.

But the laborer in Zion shall labor for Zion; for if they labor for money they shall perish.

And again, the Lord God hath commanded that men should not murder; that they should not lie; that they should not steal; that they should not take the name of the Lord their God in vain; that they should not envy; that they should not have malice; that they should not contend one with another; that they should not commit whoredoms; and that they should do none of these things; for whoso doeth them shall perish.

For none of these iniquities come of the Lord; for he doeth that which is good among the children of men; and he doeth nothing save it be plain unto the children of men; and he inviteth them all to come unto him and partake of his goodness; and he denieth none that come unto him, black and white, bond and free, male and female; and he remembereth the heathen; and all are alike unto God, both Jew and Gentile.

## 2 Нифай 27

- 1 Гэвч, болгоогтун, эцсийн өдрүүдэд, өөрөөр хэлбэл харийнханы өдрүүдэд—тийм ээ, болгоогтун харийнханы бүх үндэстнүүд мөн түүнчлэн иудейчүүд, энэ газар дээр ирэх тэд мөн бусад газрууд дээр байх тэд аль аль нь, тийм ээ, бүр дэлхийн бүх нутгууд дээр, болгоогтун, тэд алдсуудад мөн бүх төрлийн жигшүүрт хэргүүдэд согтуурах бөлгөө—
- 2 Мөн тэр өдөр ирэх болоход тэд аянга мөн газар хөдлөлт, мөн агуу дуу чимээ, мөн шуурга, мөн хуй салхи, мөн залгигч галтай түймрээр Түмний Их Эзэнээр зочлогдох болно.
- 3 Мөн Сионы эсрэг тулалдах мөн түүнийг туйлдуулах бүх үндэстнүүд шөнийн үзэгдэл зүүд лугаа адил байх болно; тийм ээ, энэ нь тэдэнд, бүр зүүдлэх өлссөн хүний адил, мөн болгоогтун тэрээр идэх гэтэл тэрээр сэрнэ мөн түүний бодгаль хоосон байна, эсвээс зүүдлэх цангасан хүний адил, мөн болгоогтун тэрээр уух гэтэл тэрээр сэрнэ, мөн болгоогтун тэр харангадах болно, мөн бодгаль нь өлсгөлөн байх болно; тийм ээ, бүр Сион Уулын эсрэг тулалддаг бүх үндэстнүүдийн хүмүүс тийн байх болно.
- 4 Учир нь болгоогтун, алдсыг үйлдэгч та нар бүгд, зогсоцгоо мөн гайхацгаа, өөрөөр хэлбэл та нар хашгирцаана, мөн уйлах болно; тийм ээ, та нар согтох болно, харин дарсанд бус, та нар хөлчүүрхэх болно, харин хүчит ундаанд бус.
- 5 Учир нь болгоогтун, Их Эзэн та нарын дээр гүн нойрны нөлөөг цутган юүлэх бөлгөө. Учир нь болгоогтун, та нар нүдээ аньж, мөн бошиглогчдыг эсэргүүцсэн; мөн та нарын алдсын учир та нарын захирагчид мөн үзмэрчдийг тэрээр халхалсан болой.
- 6 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан номны үгсийг та нарт авчрах болно, мөн тэдгээр нь үүрд нойрссон тэдний үгс байх болно.
- 7 Мөн болгоогтун ном лацдагдах болно; мөн уг номонд Бурханаас өгсөн нэгэн илчлэлт байх болно, энэ дэлхийн эхлэлээс түүний төгсгөлийг хүртэлх буюу.
- 8 Иймийн тул, лацдагдсан зүйлүүдийн учир, лацдагдсан зүйлүүд нь хүмүүсийн ёсон бус мөн жигшүүрт хэргийн өдөрт хүргэгдэхгүй бөлгөө. Иймийн тул уг ном тэднээс халхлагдах болно.

## 2 Nephi 27

But, behold, in the last days, or in the days of the Gentiles—yea, behold all the nations of the Gentiles and also the Jews, both those who shall come upon this land and those who shall be upon other lands, yea, even upon all the lands of the earth, behold, they will be drunken with iniquity and all manner of abominations—

And when that day shall come they shall be visited of the Lord of Hosts, with thunder and with earthquake, and with a great noise, and with storm, and with tempest, and with the flame of devouring fire.

And all the nations that fight against Zion, and that distress her, shall be as a dream of a night vision; yea, it shall be unto them, even as unto a hungry man which dreameth, and behold he eateth but he awaketh and his soul is empty; or like unto a thirsty man which dreameth, and behold he drinketh but he awaketh and behold he is faint, and his soul hath appetite; yea, even so shall the multitude of all the nations be that fight against Mount Zion.

For behold, all ye that doeth iniquity, stay yourselves and wonder, for ye shall cry out, and cry; yea, ye shall be drunken but not with wine, ye shall stagger but not with strong drink.

For behold, the Lord hath poured out upon you the spirit of deep sleep. For behold, ye have closed your eyes, and ye have rejected the prophets; and your rulers, and the seers hath he covered because of your iniquity.

And it shall come to pass that the Lord God shall bring forth unto you the words of a book, and they shall be the words of them which have slumbered.

And behold the book shall be sealed; and in the book shall be a revelation from God, from the beginning of the world to the ending thereof.

Wherefore, because of the things which are sealed up, the things which are sealed shall not be delivered in the day of the wickedness and abominations of the people. Wherefore the book shall be kept from them.

- 9 Гэвч уг ном нэгэн хүнд хүргэгдэнэ, мөн тэрээр газар шороонд нойрссон тэдний үгс болох тэр номын үгсийг хүргэж, мөн тэрээр эдгээр үгсийг өөр нэгэнд хүргэх болно;
- 10 Гэвч номыг хүргэхгүй бас лацдагдсан үгсийг тэрээр хүргэх нь үгүй. Учир нь уг ном Бурханы хүчээр лацдагдах болно, мөн лацдагдсан илчлэлт нь тэдгээр нь ирж болно гэсэн Их Эзэний өөрийнх нь тогтоосон цагийг хүртэл уг номонд хадгалагдах болно; учир нь болгоогтун, тэдгээр нь дэлхийн сууринаас түүний төгсгөл хүртэл бүх зүйлийг илчлэх болно.
- 11 Мөн тэр номын лацдагдсан үгс дээвэр дээрээс уншигдах тэрхүү өдөр ирнэ; мөн тэдгээр нь Христийн хүчээр уншигдах болно; мөн хүмүүний үрсийн дунд байсан тэдгээр, мөн бүр дэлхийн төгсгөлийг хүртэл байх тэдгээр бүх зүйл хүмүүний үрсэд илчлэгдэх болно.
- 12 Иймийн тул, миний ярьсан тэр хүнд уг ном хүргэгдэх тэр өдөр, уг ном дэлхийн нүднээс далдлагдах болно, тиймээс гурван гэрч үүнийг Бурханы хүчээр болгоохоос бусдаар нэг ч нүд үүнийг үзэх нь үгүй, уг ном хүргэгдэх түүнээс гадна буюу; мөн тэд уг номын мөн түүнд буй зүйлүүдийн үнэнийг гэрчлэх болно.
- 13 Мөн Бурханы тааллын дагуу байх түүний үгийг хүмүүний үрсэд гэрчлэн өгүүлэх тэр цөөн хэдээс өөр үүнийг харах бусад нь үгүй; өөрөөр хэлбэл итгэлтний үгс нас барагсдаас мэт ярихыг Их Эзэн Бурхан хэлсэн болой.
- 14 Иймийн тул, Их Эзэн Бурхан уг номын үгсийг урагш авчрахыг зорих болно; мөн тэрээр өөрийн үгийг байвал зохино хэмээсэн тооны гэрчүүдийн амаар нотлуулах болно; мөн Бурханы үгийг эсэргүүцэх түүнд халаг болох буюу.
- 15 Гэвч болгоогтун, улиран тохиох дор Их Эзэн Бурхан уг номыг өгөөд, түүнд хэлнэ: Лацдагдаагүй эдгээр үгсийг авч мөн өөр нэгэнд хүргэ, тэрээр тэдгээрийг эрдэмт нэгэнд үзүүлж болохын тулд, хэлэх нь: Үүнийг унш, би танаас гуйя. Мөн эрдэмт тэр хэлнэ: Номыг нааш авчир, мөн тэдгээрийг би уншъя гэнэ.

But the book shall be delivered unto a man, and he shall deliver the words of the book, which are the words of those who have slumbered in the dust, and he shall deliver these words unto another;

But the words which are sealed he shall not deliver, neither shall he deliver the book. For the book shall be sealed by the power of God, and the revelation which was sealed shall be kept in the book until the own due time of the Lord, that they may come forth; for behold, they reveal all things from the foundation of the world unto the end thereof.

And the day cometh that the words of the book which were sealed shall be read upon the house tops; and they shall be read by the power of Christ; and all things shall be revealed unto the children of men which ever have been among the children of men, and which ever will be even unto the end of the earth.

Wherefore, at that day when the book shall be delivered unto the man of whom I have spoken, the book shall be hid from the eyes of the world, that the eyes of none shall behold it save it be that three witnesses shall behold it, by the power of God, besides him to whom the book shall be delivered; and they shall testify to the truth of the book and the things therein.

And there is none other which shall view it, save it be a few according to the will of God, to bear testimony of his word unto the children of men; for the Lord God hath said that the words of the faithful should speak as if it were from the dead.

Wherefore, the Lord God will proceed to bring forth the words of the book; and in the mouth of as many witnesses as seemeth him good will he establish his word; and wo be unto him that rejecteth the word of God!

But behold, it shall come to pass that the Lord God shall say unto him to whom he shall deliver the book: Take these words which are not sealed and deliver them to another, that he may show them unto the learned, saying: Read this, I pray thee. And the learned shall say: Bring hither the book, and I will read them.

16 Мөн эдүгээ, дэлхийн алдар мөн эд хөрөнгө олохын тулд тэд үүнийг хэлэх болно, мөн Бурханы алдар суугийн төлөө бус болой.

17 Мөн уг хүн хэлнэ: Би номыг авчирч чадахгүй, учир нь энэ нь лацдагдсан байна.

18 Тэгэхэд эрдэмт нь хэлнэ: Би үүнийг уншиж чадахгүй.

19 Иймийн тул улиран тохиох дор, Их Эзэн Бурхан номыг мөн түүний үгсийг суралцаагүй түүнд дахин хүргэх болно; мөн тэр суралцаагүй хүн хэлнэ: Бибээр суралцаагүй.

20 Тэгэхэд Их Эзэн Бурхан түүнд хэлнэ: Эрдэмт нь тэдгээрийг үл уншина, учир нь тэд тэдгээрийг эсэргүүцэв, мөн би өөрийн ажлыг хийж чадна; иймийн тул чамд миний өгөх үгсийг чи унших болно.

21 Лацдагдсан тэдгээр зүйлүүдэд бүү хүр, учир нь би тэдгээрийг өөрийн зохих цагт гарган авчрах болно; өөрөөр хэлбэл өөрийн ажлыг би өөрөө хийж чадна гэдгийг би хүмүүний үрсэд үзүүлэх болно.

22 Иймийн тул, миний чамд зарлигласан тэдгээр үгсийг чи уншиж, мөн миний чамд амласан тэдгээр гэрчүүдийг авсны дараа, чи номыг дахин лацдана, мөн миний төлөө үүнийг далдлах болно, чиний уншаагүй үгсийг би өөрийн мэргэн ухаанд бүх зүйлийг хүмүүний үрсэд илчилбэл зохихыг хүртэл хадгалж болохын тулд буюу.

23 Учир нь болгоогтун, би бол Бурхан, мөн би бол гайхамшгуудын Бурхан; мөн энэ дэлхийд би өчигдөр, өнөөдөр, мөн үүрд адил гэдгийг би үзүүлэх болно; мөн тэдний итгэлийн дагуу байхаас бусдаар би хүмүүний үрсийн дунд ажиллах нь үгүй.

24 Мөн түүнчлэн улиран тохиох дор Их Эзэн түүнд хүргэгдэх үгсийг унших түүнд ийн хэлэх болно:

25 Энэ хүмүүс өөрсдийн амаар надад ойр болж, мөн тэдний уруул намайг алдаршуулна, харин зүрх сэтгэлээ надаас холдуулсан, мөн тэдний надад хандах айдас нь хүмүүний заавраар сургагдсаны хэрээр—

And now, because of the glory of the world and to get gain will they say this, and not for the glory of God.

And the man shall say: I cannot bring the book, for it is sealed.

Then shall the learned say: I cannot read it.

Wherefore it shall come to pass, that the Lord God will deliver again the book and the words thereof to him that is not learned; and the man that is not learned shall say: I am not learned.

Then shall the Lord God say unto him: The learned shall not read them, for they have rejected them, and I am able to do mine own work; wherefore thou shalt read the words which I shall give unto thee.

Touch not the things which are sealed, for I will bring them forth in mine own due time; for I will show unto the children of men that I am able to do mine own work.

Wherefore, when thou hast read the words which I have commanded thee, and obtained the witnesses which I have promised unto thee, then shalt thou seal up the book again, and hide it up unto me, that I may preserve the words which thou hast not read, until I shall see fit in mine own wisdom to reveal all things unto the children of men.

For behold, I am God; and I am a God of miracles; and I will show unto the world that I am the same yesterday, today, and forever; and I work not among the children of men save it be according to their faith.

And again it shall come to pass that the Lord shall say unto him that shall read the words that shall be delivered him:

Forasmuch as this people draw near unto me with their mouth, and with their lips do honor me, but have removed their hearts far from me, and their fear towards me is taught by the precepts of men—

26 Тиймийн тул, би энэ хүмүүсийн дунд гайхамшигт ажлыг, тийм ээ, ер бусын үйлийг мөн гайхамшигийг үйлдэхээр зорих болно, өөрөөр хэлбэл тэдний мэргэн ухаантны мөн суралцсаны ухаан нь мөхөх болно, мөн тэдний хэрсүү ухаантны ойлголт далдлагдах болно.

27 Мөн өөрсдийн бодол зорилгыг Их Эзэнээс нуухаар гүнийг эрэлхийлэх тэдэнд халаг! Мөн тэдний ажлууд харанхуйд байдаг; мөн тэд хэлдэг: Хэн биднийг үзэж, мөн хэн биднийг мэдэх билээ? Мөн тэд түүнчлэн хэлдэг: Гарцаагүй зүйлийг урвуулан эргүүлэх тань ваарчны шавар адил үнэлэгдэх болно. Гэвч болгоогтун, би тэдэнд үзүүлэх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг, би тэдний бүх ажлыг мэднэ гэдгийг болой. Өөрөөр хэлбэл ажил нь үүнийг хийсэн эзнээ, тэрээр намайг хийгээгүй гэх хэрэг үү? Эсвэл аливаа үйлүүд нь үйлдэгсдээ тэрээр ойлголтгүй гэх хэрэг үү

28 Түмний Их Эзэн хэлэв: Гэвч болгоогтун, Ливан шимт талбай болон хувиргагдах хүртэл бяцхан хугацаа үлдээд буйг би хүмүүний үрсэд үзүүлэх болно; мөн шимт талбай ой мэт үнэлэгдэх болно.

29 Мөн тэр өдөр дүлий нь уг номын үгсийг сонсон, мөн хараагүй нэг нь тодорхой бус байдлаас ч, мөн харанхуйгаас ч харах болно.

30 Мөн түүнчлэн номхон дөлгөөнчүүд нэмэгдэх болно, мөн тэдний баясал Их Эзэнд байх болно, мөн хүмүүний дунд ядуу нь Израилын Ариун Нэгэнд баясах болно.

31 Учир нь Их Эзэн амьд нь эргэлзээгүйн адил тэд аймшигт нэгэн хий хоосонд авчрагдахыг харах болно, мөн элэглэгч нь үрэгдэхийг, мөн алдсыг хайгч тэд бүгд тусгаарлагдахыг болой;

32 Мөн хүнийг үгээр нь хэрэгтэн болгогч, мөн олны нүдэн дээр зэмлэх түүнд урхи тавих тэднийг, мөн шударгыг хий хоосны тулд буцаах тэднийг болой.

33 Тиймийн тул Иаковын угсааныхны талаар, Абрахамыг гэтэлгэсэн Их Эзэн тийн хэлэв: Иаков эдүгээ ичих нь үгүй, басхүү түүний нүүр цонхийсон байх нь ч үгүй болой.

Therefore, I will proceed to do a marvelous work among this people, yea, a marvelous work and a wonder, for the wisdom of their wise and learned shall perish, and the understanding of their prudent shall be hid.

And wo unto them that seek deep to hide their counsel from the Lord! And their works are in the dark; and they say: Who seeth us, and who knoweth us? And they also say: Surely, your turning of things upside down shall be esteemed as the potter's clay. But behold, I will show unto them, saith the Lord of Hosts, that I know all their works. For shall the work say of him that made it, he made me not? Or shall the thing framed say of him that framed it, he had no understanding?

But behold, saith the Lord of Hosts: I will show unto the children of men that it is yet a very little while and Lebanon shall be turned into a fruitful field; and the fruitful field shall be esteemed as a forest.

And in that day shall the deaf hear the words of the book, and the eyes of the blind shall see out of obscurity and out of darkness.

And the meek also shall increase, and their joy shall be in the Lord, and the poor among men shall rejoice in the Holy One of Israel.

For assuredly as the Lord liveth they shall see that the terrible one is brought to naught, and the scorner is consumed, and all that watch for iniquity are cut off;

And they that make a man an offender for a word, and lay a snare for him that reproveth in the gate, and turn aside the just for a thing of naught.

Therefore, thus saith the Lord, who redeemed Abraham, concerning the house of Jacob: Jacob shall not now be ashamed, neither shall his face now wax pale.

34 Гэвч тэрээр өөрсдийнх нь хүүхдүүд болох миний мутраар хийгдсэн ажлыг өөрсдийнхөө дунд байхыг хараад, тэд миний нэрийг бишрэн, мөн Иаковын Ариун Нэгэнийг биширч, мөн Израилын Бурханаас эмээх болно.

35 Түүнчлэн сүнслэг байдалдаа алдаа хийгсэд, тэд ойлголтонд ирэх болно, мөн бувтнасан тэд сургаалыг суралцах болно.

But when he seeth his children, the work of my hands, in the midst of him, they shall sanctify my name, and sanctify the Holy One of Jacob, and shall fear the God of Israel.

They also that erred in spirit shall come to understanding, and they that murmured shall learn doctrine.

## 2 Нифай 28

- 1 Мөн эдүгээ, болгоогтун, ах дүү нар минь, Сүнс намайг албадсаны дагуу би та нарт ярьсан; иймийн тул, тэдгээр нь гарцаагүй улиран тохиох ёстойг би мэднэ.
- 2 Мөн уг номноос бичигдэх зүйлүүд нь хүмүүний үрсэд мөн ялангуяа Израилын угсааны үлдэгдэл болох бидний үр удамд маш чухал байх болно.
- 3 Өөрөөр хэлбэл сүмүүд Их Эзэний төлөө биш босгогдох тэр өдөр улиран тохионо, нэг нь нөгөөдөө: Болгоогтун, би, би бол Их Эзэнийх; мөн бусад нь хэлнэ; би, би бол Их Эзэнийх; мөн Их Эзэний төлөө бус сүм босгосон хүн бүр тийн хэлэх болно—
- 4 Мөн тэд өөр хоорондоо зөрчилдөх болно; мөн тэдний санваартнууд нэг нэгэнтэйгээ тэмцэх болно, мөн тэд өөрсдийн суралцсанаас заах болно, мөн зааврыг өгөх Ариун Сүнсийг үгүйсгэх болно.
- 5 Мөн тэд Израилын Ариун Нэгэн, Бурханы хүчийг үгүйсгэх болно; мөн тэд хүмүүст хэлнэ: Биднийг анхааран сонсоцгоо, мөн та нар бидний зааврыг сонсоцгоо; учир нь болгоогтун өнөөдөр Бурхан гэж үгүй, учир нь Их Эзэн мөн Гэтэлгэгч өөрийн ажлыг хийсэн билээ, мөн тэрээр хүмүүнд өөрийн хүчийг өгсөн билээ;
- 6 Болгоогтун, та нар миний зааврыг анхааран сонс; хэрэв тэд Их Эзэний мутраар гайхамшиг хийгдсэн хэмээвэл үүнд бүү итгэ; учир нь энэ өдөр тэр бол гайхамшгуудын Бурхан биш; тэрээр өөрийн ажлыг хийчихсэн шүү дээ.
- 7 Тийм ээ, мөн ийнхүү хэлэх нь олон байх болно: Ид, уу, мөн баяс, учир нь маргааш бид үхнэ; мөн энэ нь бидэнд сайн байх болно.
- 8 Мөн үүнчлэн ийнхүү хэлэх нь олон байна: Ид, уу, мөн баяс; гэсэн хэдий ч, Бурханаас эмээ—тэр бяцхан нүгэл үйлдсэнийг зөвтгөнө; тийм ээ, бяцхан худал хэл, өөр нэгийг түүний үгсийнх нь учир далимдуул, хөршүүддээ нүх малт; үүнд хор хөнөөл гэж үгүй; мөн эдгээр бүх зүйлийг хий, учир нь маргааш бид үхнэ; мөн хэрэв түүнчлэн байснаар бид буруутай аваас, Бурхан биднийг хэдхэн удаа ташуурдах болно, мөн эцэст нь бид Бурханы хаант улсад аврагдах болно.

## 2 Nephi 28

And now, behold, my brethren, I have spoken unto you, according as the Spirit hath constrained me; wherefore, I know that they must surely come to pass.

And the things which shall be written out of the book shall be of great worth unto the children of men, and especially unto our seed, which is a remnant of the house of Israel.

For it shall come to pass in that day that the churches which are built up, and not unto the Lord, when the one shall say unto the other: Behold, I, I am the Lord's; and the others shall say: I, I am the Lord's; and thus shall every one say that hath built up churches, and not unto the Lord—

And they shall contend one with another; and their priests shall contend one with another, and they shall teach with their learning, and deny the Holy Ghost, which giveth utterance.

And they deny the power of God, the Holy One of Israel; and they say unto the people: Harken unto us, and hear ye our precept; for behold there is no God today, for the Lord and the Redeemer hath done his work, and he hath given his power unto men;

Behold, hearken ye unto my precept; if they shall say there is a miracle wrought by the hand of the Lord, believe it not; for this day he is not a God of miracles; he hath done his work.

Yea, and there shall be many which shall say: Eat, drink, and be merry, for tomorrow we die; and it shall be well with us.

And there shall also be many which shall say: Eat, drink, and be merry; nevertheless, fear God—he will justify in committing a little sin; yea, lie a little, take the advantage of one because of his words, dig a pit for thy neighbor; there is no harm in this; and do all these things, for tomorrow we die; and if it so be that we are guilty, God will beat us with a few stripes, and at last we shall be saved in the kingdom of God.



9 Тийм ээ, мөн тэд ийм маягаар, хуурамч мөн хоосон мөн мунхаг сургаалуудыг заах бөлгөө, мөн зүрх сэтгэлдээ ихэмсэглэдэг, мөн бодол санаагаа Их Эзэнээс нуухаар гүнзгийг эрэлхийлэх тэд олон байх болно; мөн тэдний ажлууд харанхуйд байх болно.

10 Мөн гэгээнтнүүдийн цус газраас тэдний эсрэг хашгирах болно.

11 Тийм ээ, тэд бүгд замаас гарч оджээ; тэд завхарчээ.

12 Бардамналын учир, мөн хуурамч багш нарын, мөн хуурамч сургаалын учир, тэдний сүмүүд ялзарчээ, мөн тэдний сүмүүд ихэмсэглэдэг; бардамналын учир тэд ихэмсэг болжээ.

13 Тэд ядууг дээрэмдэн, өөрсдийн сайхан дуганы учир буюу; тэд ядууг дээрэмддэг, өөрсдийн сайхан хувцасны улмаас буюу; мөн тэд номхон дөлгөөнчүүдийг мөн ядуу зүрхтэйг хавчдаг, тэд бардамналдаа ихэмсэглэсний учир буюу.

14 Тэд хүзүүгээ гаанайлган мөн дээгүүр хардаг; тийм ээ, мөн бардамналын, мөн ёсон бус, мөн жигшүүрт хэрэг, мөн садар самууны учир, Христийн даруу дагалдагчид болох цөөн хэдээс бусад нь тэд бүгд төөрөлдөн одсон бөлгөө; гэсэн хэдий ч тэд удирдагдана олон тохиолдолд тэд хүмүүний дүрмүүдээр сургагдсан учир тэд алдаа гаргадаг.

15 Ай сэтгэл дэх бардамналдаа ихэмсэглэсэн мэргэн ухаантнууд, мөн эрдэмтэд, мөн баячууд, мөн хуурамч сургаалуудыг номлох тэд бүгд, мөн садар самууныг үйлдэх мөн Их Эзэний зөв замыг гажуудуулах тэд бүгд, тэдэнд халаг, халаг, халаг болог, учир нь тэд тамд доош түлхэгдэх болно хэмээн Их Эзэн Бүхнийг Чадагч Бурхан хэлдэг!

16 Хий хоосны төлөө шударгыг буцаах мөн сайны эсрэг арцалдах, мөн энэ нь чухал бус гэж хэлэх тэдэнд халаг! Учир нь Их Эзэн Бурхан дэлхийн оршин суугчдад гэнэт айлчлах тэр өдөр ирэх болно; мөн тэд алдаст бүрэн боловсорсон тэр өдөр тэд мөхөх болно.

17 Гэвч болгоогтун, хэрэв дэлхийн оршин суугчид өөрсдийн ёс бус явдлууд мөн жигшүүрт хэргүүдээсээ наманчилбаас тэд устгагдахгүй байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлжээ.

Yea, and there shall be many which shall teach after this manner, false and vain and foolish doctrines, and shall be puffed up in their hearts, and shall seek deep to hide their counsels from the Lord; and their works shall be in the dark.

And the blood of the saints shall cry from the ground against them.

Yea, they have all gone out of the way; they have become corrupted.

Because of pride, and because of false teachers, and false doctrine, their churches have become corrupted, and their churches are lifted up; because of pride they are puffed up.

They rob the poor because of their fine sanctuaries; they rob the poor because of their fine clothing; and they persecute the meek and the poor in heart, because in their pride they are puffed up.

They wear stiff necks and high heads; yea, and because of pride, and wickedness, and abominations, and whoredoms, they have all gone astray save it be a few, who are the humble followers of Christ; nevertheless, they are led, that in many instances they do err because they are taught by the precepts of men.

O the wise, and the learned, and the rich, that are puffed up in the pride of their hearts, and all those who preach false doctrines, and all those who commit whoredoms, and pervert the right way of the Lord, wo, wo, wo be unto them, saith the Lord God Almighty, for they shall be thrust down to hell!

Wo unto them that turn aside the just for a thing of naught and revile against that which is good, and say that it is of no worth! For the day shall come that the Lord God will speedily visit the inhabitants of the earth; and in that day that they are fully ripe in iniquity they shall perish.

But behold, if the inhabitants of the earth shall repent of their wickedness and abominations they shall not be destroyed, saith the Lord of Hosts.

18 Гэвч болгоогтун, тэр агуу хийгээд жигшүүрт сүм, бүх дэлхийн садар эм, газарт шурган унах ёстой, мөн түүний уналт агуу байх ёстой.

19 Учир нь чөтгөрийн хаант улс салгалах ёстой, мөн үүнд харъяалагдах тэд наманчлалд өдөөн хатгагдах ёстой нь зайлшгүй, эс тэгвээс чөтгөр тэднийг өөрийн үүрдийн гинжээр боймлож, мөн тэд уур хилэнд өдөөгдөж мөн мөхөх болно.

20 Учир нь болгоогтун, тэр өдөр тэрээр хүмүүний үрсийн зүрхэнд улангасч, мөн сайн болох түүний эсрэг тэднийг уурлуулан өдөөх болно.

21 Мөн бусад заримыг тэрээр тайтгаруулж, мөн зуурдын аюулгүй байдалд тэднийг тайвшруулахад, тэд: Сионд бүх юм зүгээр; тийм ээ, Сион дэгжинэ, бүх юм зүгээр гэнэ—мөн чөтгөр тийн тэдний бодгалийг хуурч, мөн тэднийг болгоомжтойгоор там уруу удирдах болно.

22 Мөн болгоогтун, тэрээр бусад заримыг зусардан, мөн тэдэнд там гэж үгүй хэмээн хэлдэг; мөн тэрээр тэдэнд: Би бол чөтгөр биш, учир нь тийм юм гэж үгүй гэдэг—мөн тэрээр тэднийг чөлөөлөгдөх нь үгүй өөрийн аймшигт гинжээр хүлж автлаа хүмүүний үрсэд чихэнд нь тийн шивнэх болно.

23 Тийм ээ, тэд үхэлд, мөн тамд боймлогдсон; мөн үхэл, болон там, мөн сайхь чөтгөр, мөн түүгээр шүүрэгдсэн тэд бүгд Бурханы сэнтийний өмнө зогсож, мөн үйлүүдийнхээ дагуу шүүгдэх ёстой, тэндээс тэд өөрсөддөө бэлтгэгдсэн тэр газарт очих ёстой, бүр төгсгөлгүй тарчлал болох тэрхүү хүхрийн чулуут мөн галт нуурт болой.

24 Тиймийн тул, Сионд сэрэмжгүй байгч түүнд халаг!

25 Бүх юм зүгээр гэж хашгирах түүнд халаг!

26 Тийм ээ, хүмүүний зааврыг анхааран сондог, мөн Бурханы хүчийг, мөн Ариун Сүнсний бэлгийг үгүйсгэдэг түүнд халаг!

27 Тийм ээ, ийн хэлдэг: бид хүлээн авчихсан, мөн бидэнд илүү хэрэггүй хэмээн хэлэх түүнд халаг!

28 Мөн чухамдаа, Бурханы үнэний учир уурлах, мөн салгалах тэд бүгдэд халаг! Учир нь болгоогтун, хадан дээр баригдсан тэр нь үүнийг баяртайгаар хүлээн авдаг; мөн элсэн суурин дээр баригдсан тэр нь унах болуузай хэмээн айж салгалах ажгуу.

But behold, that great and abominable church, the whore of all the earth, must tumble to the earth, and great must be the fall thereof.

For the kingdom of the devil must shake, and they which belong to it must needs be stirred up unto repentance, or the devil will grasp them with his everlasting chains, and they be stirred up to anger, and perish;

For behold, at that day shall he rage in the hearts of the children of men, and stir them up to anger against that which is good.

And others will he pacify, and lull them away into carnal security, that they will say: All is well in Zion; yea, Zion prospereth, all is well—and thus the devil cheateth their souls, and leadeth them away carefully down to hell.

And behold, others he flattereth away, and telleth them there is no hell; and he saith unto them: I am no devil, for there is none—and thus he whispereth in their ears, until he grasps them with his awful chains, from whence there is no deliverance.

Yea, they are grasped with death, and hell; and death, and hell, and the devil, and all that have been seized therewith must stand before the throne of God, and be judged according to their works, from whence they must go into the place prepared for them, even a lake of fire and brimstone, which is endless torment.

Therefore, wo be unto him that is at ease in Zion!

Wo be unto him that crieth: All is well!

Yea, wo be unto him that hearkeneth unto the precepts of men, and denieth the power of God, and the gift of the Holy Ghost!

Yea, wo be unto him that saith: We have received, and we need no more!

And in fine, wo unto all those who tremble, and are angry because of the truth of God! For behold, he that is built upon the rock receiveth it with gladness; and he that is built upon a sandy foundation trembleth lest he shall fall.

- 29 Бид Бурханы үгийг хүлээн авсан, мөн Бурханаас өөр үг бидэнд хэрэггүй, учир нь бидэнд хангалттай буй гэж хэлэх түүнд халаг!
- 30 Их Эзэн Бурхан хэлэв: Учир нь болгоогтун, би хүмүүний үрст шат шатаар, дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг өгөх болно; мөн миний дүрмүүдийг анхааран сонсох, мөн миний зааварт чих тавих тэд адислагдсан болой, учир нь тэд мэргэн ухаанд суралцах болно; өөрөөр хэлбэл хүлээн авах түүнд би илүүг өгөх болно; мөн бидэнд хангалттай буй хэмээн хэлэх тэднээс бүр тэдэнд байгаа нь ч авагдах болно.
- 31 Хүмүүнд итгэдэг, эсвээс маханбодиос бүтэх гартаа итгэдэг, эсвээс Ариун Сүнсний хүчээр өгөгдөх тэдний заавруудаас гадна бол хүмүүний заавруудыг анхааран сонсдог тэд зүхэгдсэн болой.
- 32 Харийнханд халаг түмний Их Эзэн Бурхан хэлдэг хэмээн! Учир нь би мутраа өдрөөс өдөрт тэдэнд сунгах хэдий ч, тэд намайг үгүйсгэх болно; Их Эзэн Бурхан хэлсэн нь, гэсэн хэдий ч хэрэв тэд наманчилж мөн надад ирэх аваас би тэдэнд нигүүлсэнгүй хандах болно; өөрөөр хэлбэл миний мутар бүх өдрийн туршид сунгаастай байх болно хэмээн Түмний Их Эзэн Бурхан хэлдэг.

Wo be unto him that shall say: We have received the word of God, and we need no more of the word of God, for we have enough!

For behold, thus saith the Lord God: I will give unto the children of men line upon line, precept upon precept, here a little and there a little; and blessed are those who hearken unto my precepts, and lend an ear unto my counsel, for they shall learn wisdom; for unto him that receiveth I will give more; and from them that shall say, We have enough, from them shall be taken away even that which they have.

Cursed is he that putteth his trust in man, or maketh flesh his arm, or shall hearken unto the precepts of men, save their precepts shall be given by the power of the Holy Ghost.

Wo be unto the Gentiles, saith the Lord God of Hosts! For notwithstanding I shall lengthen out mine arm unto them from day to day, they will deny me; nevertheless, I will be merciful unto them, saith the Lord God, if they will repent and come unto me; for mine arm is lengthened out all the day long, saith the Lord God of Hosts.

## 2 Нифай 29

- 1 Гэвч болгоогтун, олон нь байх болно—би хүмүүний үрстэй хийсэн өөрийн гэрээнүүдийг санаж болохын тулд, Израилын угсаа болох өөрийн хүмүүсийг буцааж авахын тулд би мутраа хоёр дахь удаагаа дахин хөдөлгөж болохын тулд би тэдний дунд гайхамшигт ажил хийхээр зорих тэрхүү өдөр буюу;
- 2 Мөн түүнчлэн, би та нарын үр удмыг санана хэмээн Нифай чамд, мөн түүнчлэн чиний эцэгт амласнаа санаж болохын тулд; мөн таны үр удмын үгс чиний үр удамд чинь миний амаар шилжин ирэх болно; мөн миний үгс дэлхийн өнцөг булан бүрд, Израилын угсаа болох миний хүмүүст далбаа болж исгэрэх болно;
- 3 Мөн миний үгс исгэрэн ирэх учир—харийнханаас олон нь хэлнэ: Ай Библи! Ай Библи! Бидэнд Библи байгаа билээ, мөн өөр ямар ч Библи байж болохгүй.
- 4 Гэвч Их Эзэн Бурхан тийн хэлэв: Ай мунхгууд, тэд Библитэй байх болно; мөн энэ нь миний эртний гэрээт хүмүүс болох иудейчүүдээс гарч ирэх болно. Мөн тэднээс хүлээж авсан тэр Библийн учир иудейчүүдэд тэд хэрхэн талархах билээ? Тийм ээ харийнхан ямар бодолтой билээ? Тэд харийнханд авралыг авчрахын тул иудейчүүдийн тарчлалыг мөн хөдөлмөрийг, мөн шаналлыг, мөн тэдний надад хандсан хичээнгүйллийг санадаг уу
- 5 Ай харийнхан та нар, та нар миний эртний гэрээт хүмүүс иудейчүүдийг санасан уу? Үгүй; харин та нар тэднийг зүхэн, мөн тэднийг үзэн ядсан, мөн тэднийг буцаан авчрахыг эрэлхийлээгүй. Гэвч болгоогтун, би эдгээр бүх зүйлийг та нарын өөрсдийн тань тэргүүн дээр эргүүлэх болно; учир нь Их Эзэн би өөрийн хүмүүсийг мартаагүй.
- 6 Мунхаг та нар, ийн хэлдэг: Ай Библи, бидэнд Библи байгаа, мөн бидэнд өөр ямар ч Библи хэрэггүй. Иудейчүүдээр бус аваас та нар Библийг олох байсан гэж үү

## 2 Nephi 29

But behold, there shall be many—at that day when I shall proceed to do a marvelous work among them, that I may remember my covenants which I have made unto the children of men, that I may set my hand again the second time to recover my people, which are of the house of Israel;

And also, that I may remember the promises which I have made unto thee, Nephi, and also unto thy father, that I would remember your seed; and that the words of your seed should proceed forth out of my mouth unto your seed; and my words shall hiss forth unto the ends of the earth, for a standard unto my people, which are of the house of Israel;

And because my words shall hiss forth—many of the Gentiles shall say: A Bible! A Bible! We have got a Bible, and there cannot be any more Bible.

But thus saith the Lord God: O fools, they shall have a Bible; and it shall proceed forth from the Jews, mine ancient covenant people. And what thank they the Jews for the Bible which they receive from them? Yea, what do the Gentiles mean? Do they remember the travails, and the labors, and the pains of the Jews, and their diligence unto me, in bringing forth salvation unto the Gentiles?

O ye Gentiles, have ye remembered the Jews, mine ancient covenant people? Nay; but ye have cursed them, and have hated them, and have not sought to recover them. But behold, I will return all these things upon your own heads; for I the Lord have not forgotten my people.

Thou fool, that shall say: A Bible, we have got a Bible, and we need no more Bible. Have ye obtained a Bible save it were by the Jews?

7 Та нар нэгээс илүү үндэстнүүд байдгийг мэдэхгүй гэж үү? Би, Их Эзэн та нарын Бурхан бүх хүмүүнийг бүтээсэн, мөн би далайн арлууд дээрх тэднийг санахыг, мөн би дээр тэнгэрт мөн доор газарт захирдгийг; мөн би өөрийн үгийг хүмүүний үрст, тийм ээ, бүр дэлхийн бүх үндэстний дээр авчрах тэр мөн гэдгийг та нар эс мэднэ гэж үү

8 Иймийн тул бувтналдах та нар, миний үгээс ихийг хүлээн авахын учир юм уу? Хоёр үндэстний гэрчлэл би бол Бурхан, би нэг үндэстний адил нөгөөг ч санахыг та нарт гэрчилж буйг та нар эс мэднэ гэж үү? Иймийн тул, нэг үндэстний адил нөгөө үндэстэнд би адил үгсийг ярьдаг болой. Мөн хоёр үндэстэн хамтран нэгдэх үед хоёр үндэстний гэрчлэл түүнчлэн хамтран нэгдэх болно.

9 Мөн би бол өчигдөр, өнөөдөр, мөн үүрд нэгэн адил; мөн би өөрийн үгсийг тааллынхаа дагуу ярьдгийг олонд баталж болохын тулд би үүнийг хийдэг. Мөн би нэг үг ярьсан учир та нар намайг өөрийг хэлж чадахгүй хэмээн бодсоны хэрэггүй; өөрөөр хэлбэл миний ажил хараахан дуусаагүй байна; бас хүү энэ нь хүмүүний төгсгөл хүртэл ийн байх нь үгүй, мөн тэр цагаас мөн үүрд дуусахгүй байх болно.

10 Иймийн тул, та нарт Библи буй хэдий ч та нар энэ нь миний бүх үгсийг тээсэн гэж бодох хэрэггүй; бас та нар би өөрийг бичүүлсэн байх учиргүй хэмээн бодох хэрэггүй.

11 Өөрөөр хэлбэл би бүх хүмүүнд, өрнөдөд мөн дорнодод аль алинд нь, мөн өмнөдөд бас умардад мөн далайн арлуудад, тэд миний тэдэнд ярих тэдгээр үгсийг бичихийг зарлиг болгодог; өөрөөр хэлбэл бичигдэх тэр номнуудаас би дэлхийг, шүүнэ, хүн бүрийг тэдний үйлүүдийнх нь дагуу, бичигдсэн түүний дагуу болой.

12 Учир нь болгоогтун, би иудейчүүдэд ярьж мөн тэд үүнийг бичих болно; мөн би түүнчлэн нифайчуудад ярих болно мөн тэд үүнийг бичих болно; мөн түүнчлэн өөрийн гадагш удирдсан тэр Израилын угсааны бусад овгуудад би ярих болно, мөн тэд үүнийг бичих болно; мөн би түүнчлэн дэлхийн бүх үндэстнүүдэд ярих болно, мөн тэд үүнийг бичих болно.

Know ye not that there are more nations than one? Know ye not that I, the Lord your God, have created all men, and that I remember those who are upon the isles of the sea; and that I rule in the heavens above and in the earth beneath; and I bring forth my word unto the children of men, yea, even upon all the nations of the earth?

Wherefore murmur ye, because that ye shall receive more of my word? Know ye not that the testimony of two nations is a witness unto you that I am God, that I remember one nation like unto another? Wherefore, I speak the same words unto one nation like unto another. And when the two nations shall run together the testimony of the two nations shall run together also.

And I do this that I may prove unto many that I am the same yesterday, today, and forever; and that I speak forth my words according to mine own pleasure. And because that I have spoken one word ye need not suppose that I cannot speak another; for my work is not yet finished; neither shall it be until the end of man, neither from that time henceforth and forever.

Wherefore, because that ye have a Bible ye need not suppose that it contains all my words; neither need ye suppose that I have not caused more to be written.

For I command all men, both in the east and in the west, and in the north, and in the south, and in the islands of the sea, that they shall write the words which I speak unto them; for out of the books which shall be written I will judge the world, every man according to their works, according to that which is written.

For behold, I shall speak unto the Jews and they shall write it; and I shall also speak unto the Nephites and they shall write it; and I shall also speak unto the other tribes of the house of Israel, which I have led away, and they shall write it; and I shall also speak unto all nations of the earth and they shall write it.

13 Мөнхүү улиран тохиох дор иудейчүүдэд нифайчуудын үгс байх болно, мөн нифайчуудад иудейчүүдийн үгс байх болно; мөн нифайчууд мөн иудейчүүдэд Израилын алдагдсан овгуудын үгс байх болно; мөн Израилын алдагдсан овгуудад нифайчууд хийгээд иудейчүүдийн үгс байх болно.

14 Мөнхүү улиран тохиох дор Израилын угсааных болох миний хүмүүс өөрсдийн эзэмшлийн нутагт, гэртээ цуглуулагдах болно; мөн миний үг түүнчлэн нэгд цуглуулагдах болно. Мөн миний үгийн эсрэг мөн Израилын угсааных болох миний хүмүүсийн эсрэг тулалдах тэдэнд, би бол Бурхан мөн би үр удмыг нь үүрд санана хэмээн Абрахамтай би гэрээ хийснийг үзүүлэх болно.

And it shall come to pass that the Jews shall have the words of the Nephites, and the Nephites shall have the words of the Jews; and the Nephites and the Jews shall have the words of the lost tribes of Israel; and the lost tribes of Israel shall have the words of the Nephites and the Jews.

And it shall come to pass that my people, which are of the house of Israel, shall be gathered home unto the lands of their possessions; and my word also shall be gathered in one. And I will show unto them that fight against my word and against my people, who are of the house of Israel, that I am God, and that I covenanted with Abraham that I would remember his seed forever.

## 2 Нифай 30

- 1 Мөн эдүгээ болгоогтун, хайрт ах дүү нар минь, би та нарт ярья: учир нь би, Нифай, та нар харийнханы байдгаас илүү зөв шударга хэмээн бодохыг тань зөвшөөрөхгүй. Учир нь болгоогтун, та нар Бурханы зарлигуудыг дагахгүй бол та бүгд ч бас тийнхүү эрсдэх болно; мөн яригдсан үгсийн учир та нар харийнхан бүрмөсөн устгагдсан хэмээн бодох хэрэггүй.
- 2 Учир нь болгоогтун, харийханаас наманчлах болгон нь Их Эзэний гэрээт хүмүүс гэдгийг би та нарт хэлье; мөн иудейчүүдээс наманчлахгүй олон нь зайлуулагдах болно; учир нь нүглээ наманчилж мөн Израилын Ариун Нэгэн болох, түүний Хүүд итгэх тэднээс өөр хэнтэй ч Их Эзэн гэрээ хийхгүй болой.
- 3 Мөн эдүгээ, би иудейчүүд болон харийнханы талаар өөр зарим зүйлийг бошиглох сон. Өөрөөр хэлбэл миний ярьсан уг ном гарч ирэн мөн харийнханд бичигдэн мөн Их Эзэнд дахин лацдагдсаны дараа, бичигдсэн тэдгээр үгсэд итгэх нь олон байх болно; мөн тэд тэдгээрийг манай үр удмын үлдэгдэлд дамжуулах болно.
- 4 Мөн чингээд бидний үр удмын үлдэгдэл бидний талаар, бид хэрхэн Иерусалимаас гарч ирснийг, мөн тэд Иудейн удам болохыгоо мэдэх болно.
- 5 Мөн Есүс Христийн сайн мэдээ тэдний дунд тунхаглагдах болно; иймийн тул, тэд эцэг өвгөдийнхөө мэдлэгт, мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө дунд байсан Есүс Христийн тухай мэдлэгт сэргээгдэх болно.
- 6 Мөн чингээд тэд баясна; учир нь энэ нь Бурханы мутраас тэдэнд ирэх адислал гэдгийг тэд мэдэх болно; мөн тэдний харанхуйн тортог мэлмийгээс нь унаж эхлэх болно; мөн тэд цэвэр ариун мөн бахдам сайхан хүмүүс байхаас бусдаар, олон үе тэдний дунд улиран одохгүй болой.
- 7 Мөнхүү улиран тохиох дор бусниулагдсан тэдгээр иудейчүүд түүнчлэн Христэд итгэж эхлэх болно; мөн тэд уг нутгийн гадаргуу дээр цуглаж эхлэх болно; мөн Христэд итгэх болгон нь түүнчлэн бахдам сайхан хүмүүс болох бөлгөө.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан дэлхий дээрх өөрийн хүмүүсийн сэргээлтийг гүйцэлдүүлэхийн тулд өөрийн ажлыг бүх үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүсийн дунд эхлэх болно.

## 2 Nephi 30

And now behold, my beloved brethren, I would speak unto you; for I, Nephi, would not suffer that ye should suppose that ye are more righteous than the Gentiles shall be. For behold, except ye shall keep the commandments of God ye shall all likewise perish; and because of the words which have been spoken ye need not suppose that the Gentiles are utterly destroyed.

For behold, I say unto you that as many of the Gentiles as will repent are the covenant people of the Lord; and as many of the Jews as will not repent shall be cast off; for the Lord covenanteth with none save it be with them that repent and believe in his Son, who is the Holy One of Israel.

And now, I would prophesy somewhat more concerning the Jews and the Gentiles. For after the book of which I have spoken shall come forth, and be written unto the Gentiles, and sealed up again unto the Lord, there shall be many which shall believe the words which are written; and they shall carry them forth unto the remnant of our seed.

And then shall the remnant of our seed know concerning us, how that we came out from Jerusalem, and that they are descendants of the Jews.

And the gospel of Jesus Christ shall be declared among them; wherefore, they shall be restored unto the knowledge of their fathers, and also to the knowledge of Jesus Christ, which was had among their fathers.

And then shall they rejoice; for they shall know that it is a blessing unto them from the hand of God; and their scales of darkness shall begin to fall from their eyes; and many generations shall not pass away among them, save they shall be a pure and a delightsome people.

And it shall come to pass that the Jews which are scattered also shall begin to believe in Christ; and they shall begin to gather in upon the face of the land; and as many as shall believe in Christ shall also become a delightsome people.

And it shall come to pass that the Lord God shall commence his work among all nations, kindreds, tongues, and people, to bring about the restoration of his people upon the earth.

9 Мөн Их Эзэн Бурхан зөв шударгаар ядууг шүүж, мөн дэлхийн номхон дөлгөөнчүүдийн төлөө тэгш эрхтэйгээр зэмлэл хүлээлгэх болно. Мөн тэрээр үгэн саваагаараа дэлхийг цохино; мөн уруул давах амьсгаагаар тэр ёсон бусыг үйлдэгчдийг хөнөөх болно.

10 Өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан агуу ялгалтыг хүмүүсийн дунд гүйцэтгэж мөн ёсон бусыг үйлдэгчдийг тэрээр устгах тэрхүү цаг гэнэт ирнэ; мөн тэрээр өөрийн хүмүүсийг хэлтрүүлэх болно, тийм ээ, хэрэв тэрээр ёсон бусыг үйлдэгчдийг түймрээр устгах ёстой байсан ч адил буюу.

11 Мөн зөв шударга байдал түүний хэвлийн тус бүслэгдэж, мөн итгэлт байдал түүний ташаан тус бүслэгдэх болно.

12 Мөн чингээд чоно хургатай хамт орших болно; мөн ирвэс ишигтэй хамт хэвтэж, мөн тугал, мөн залуу арслан, мөн зулзага хамтдаа байна; мөн бяцхан хүүхэд тэднийг хариулах болно.

13 Мөн үнээ болон баавгай цуг идэшлэн, үр төл нь хамтдаа хэвтэх болно; мөн арслан шар лугаа адил дэрс идэх болно.

14 Мөн хөхүүл хүүхэд наж могойн нүхэн дээр тоглох болно, мөн бойжсон хүүхэд гараа хорт могойн үүрэн дээр тавих болно.

15 Тэд миний бүх ариун ууланд гэмтэх хийгээд устгах нь үгүй; учир нь тэнгис усаар бүрхэгдсэн мэт газар дэлхий Их Эзэний мэдлэгээр дүүргэгдэх болно.

16 Иймийн тул, бүх үндэстний зүйлүүд илэрхий болгогдох болно; тийм ээ, бүх зүйл хүмүүний үрсэд илэрхий болгогдох болно.

17 Илчлэгдэхээс гадуур нууц байх нь үгүй; гэрэлд үзүүлэгдэхээс гадуур ямар ч харанхуйн ажил гэж үгүй байна; мөн дэлхий дээр нээгдсэнээс гадуур ямар ч битүүмжлэгдсэн нь байхгүй болно.

18 Иймийн тул, хүмүүний үрсэд илчлэгдсэн тэдгээр бүх зүйл тэр өдөр илчлэгдэх болно; мөн Сатан хүмүүний үрсийн зүрхийг давах хүчийг удаан хугацааны турш эзэмшихгүй байх болно. Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, би өөрийн хэлэхийг төгсгөл болгоё.

And with righteousness shall the Lord God judge the poor, and reprove with equity for the meek of the earth. And he shall smite the earth with the rod of his mouth; and with the breath of his lips shall he slay the wicked.

For the time speedily cometh that the Lord God shall cause a great division among the people, and the wicked will he destroy; and he will spare his people, yea, even if it so be that he must destroy the wicked by fire.

And righteousness shall be the girdle of his loins, and faithfulness the girdle of his reins.

And then shall the wolf dwell with the lamb; and the leopard shall lie down with the kid, and the calf, and the young lion, and the fatling, together; and a little child shall lead them.

And the cow and the bear shall feed; their young ones shall lie down together; and the lion shall eat straw like the ox.

And the sucking child shall play on the hole of the asp, and the weaned child shall put his hand on the cockatrice's den.

They shall not hurt nor destroy in all my holy mountain; for the earth shall be full of the knowledge of the Lord as the waters cover the sea.

Wherefore, the things of all nations shall be made known; yea, all things shall be made known unto the children of men.

There is nothing which is secret save it shall be revealed; there is no work of darkness save it shall be made manifest in the light; and there is nothing which is sealed upon the earth save it shall be loosed.

Wherefore, all things which have been revealed unto the children of men shall at that day be revealed; and Satan shall have power over the hearts of the children of men no more, for a long time. And now, my beloved brethren, I make an end of my sayings.



## 2 Нифай 3 1

- 1 Мөн эдүгээ би, Нифай, та нарт бошиглохоо төгсгөл болгоё, хайрт ах дүү нар минь. Мөн гарцаагүй улиран тохиох ёстойг нь би мэдэх тэр цөөн зүйлээс бусдыг би бичиж чадахгүй; бас миний дүү Иаковын үгсээс цөөн хэдээс бусдыг нь би бичиж чадахгүй.
- 2 Иймийн тул Христийн сургаалын талаар миний ярих ёстой цөөн үгсээс гадна бол миний бичсэн зүйлүүд надад хангалттай; иймийн тул, би та нарт тодорхойгоор, бошиглолынхоо бүрэн тодорхой байдлын дагуу ярих болно.
- 3 Учир нь тодорхой байдалд бодгаль минь баяснам; өөрөөр хэлбэл энэ маягаар Их Эзэн Бурхан хүмүүний дунд ажил хийдэг болой. Өөрөөр хэлбэл Их Эзэн Бурхан оюун ухаанд гэрэл өгдөг; өөрөөр хэлбэл тэрээр хүмүүнд өөрсдийнх нь хэлний дагуу тэдэнд ойлгогдохоор ярьдаг.
- 4 Иймийн тул, энэ дэлхийн нүглүүдийг зайлуулах ёстой Бурханы Хурганд баптисм хүртээвэл зохих тэр, Их Эзэн надад үзүүлсэн сайхь бошиглогчийн талаар та нарт миний ярьсныг та нар санаасай хэмээнэ би.
- 5 Мөн эдүгээ, хэрэв Бурханы Хурга, ариун тэрээр, бүх зөв шударгыг гүйцэлдүүлэхийн тулд усаар баптисм хүртэх хэрэгтэй байсан аваас, Ай тэгвэл, ариун бус бид, баптисм хүртэх нь хичнээн илүү хэрэгтэй билээ, тийм ээ, бүр усаар шүү!
- 6 Мөн эдүгээ, би, та нараас асууя, хайрт ах дүү нар минь, Бурханы Хурга баптисм хүртсэнээр бүх зөв шударгыг хэрхэн гүйцэлдүүлэх билээ
- 7 Тэр бээр ариун байсныг та нар мэдэхгүй гэж үү? Гэвч тэр ариун байсан боловч, маханбодийн дагуу тэрээр Эцэгийн өмнө өөрийгөө даруусгахаа, мөн тэрээр түүний зарлигуудыг дагахаар түүнд дуулгавартай байх болно гэдгээ Эцэгт гэрчлэхээ хүмүүний үрст үзүүлсэн юм.
- 8 Иймийн тул, тэрээр баптисм хүртсэний дараа Ариун Сүнс түүний дээр тагтаа хэлбэрээр бууж ирсэн бөлгөө.
- 9 Мөн үүнчлэн, энэ нь хүмүүний үрст тэдний орох ёстой замын давчууг, мөн хаалганы нарийныг үзүүлдэг, тэдний өмнө тэрээр үлгэрлэн үзүүлсний учир болой.

## 2 Nephi 3 1

And now I, Nephi, make an end of my prophesying unto you, my beloved brethren. And I cannot write but a few things, which I know must surely come to pass; neither can I write but a few of the words of my brother Jacob.

Wherefore, the things which I have written sufficeth me, save it be a few words which I must speak concerning the doctrine of Christ; wherefore, I shall speak unto you plainly, according to the plainness of my prophesying.

For my soul delighteth in plainness; for after this manner doth the Lord God work among the children of men. For the Lord God giveth light unto the understanding; for he speaketh unto men according to their language, unto their understanding.

Wherefore, I would that ye should remember that I have spoken unto you concerning that prophet which the Lord showed unto me, that should baptize the Lamb of God, which should take away the sins of the world.

And now, if the Lamb of God, he being holy, should have need to be baptized by water, to fulfil all righteousness, O then, how much more need have we, being unholy, to be baptized, yea, even by water!

And now, I would ask of you, my beloved brethren, wherein the Lamb of God did fulfil all righteousness in being baptized by water?

Know ye not that he was holy? But notwithstanding he being holy, he showeth unto the children of men that, according to the flesh he humbleth himself before the Father, and witnesseth unto the Father that he would be obedient unto him in keeping his commandments.

Wherefore, after he was baptized with water the Holy Ghost descended upon him in the form of a dove.

And again, it showeth unto the children of men the straitness of the path, and the narrowness of the gate, by which they should enter, he having set the example before them.

10 Мөн тэрээр хүмүүний үрст: Та нар намайг дагаг-  
тун хэмээсэн бөлгөө. Иймийн тул, хайрт ах дүү нар  
минь, бид Эцэгийн зарлигуудыг сахихдаа бэлэн бай-  
хаас бусдаар бид Есүсийг дагаж чадах уу

11 Мөн Эцэг хэлэхдээ: Наманчил та нар, наманчил  
та нар, мөн миний Хайрлагдсан Хүүгийн нэрээр  
баптисм хүртэгтүн гэжээ.

12 Мөн түүнчлэн, Хүүгийн дуу хоолой надад ирж,  
хэлрүүн: Миний нэрээр баптисм хүртэх тэрээр, на-  
дад өгсний адилаар Эцэг түүнд Ариун Сүнс өгөх  
болно; иймийн тул, намайг дага, мөн миний хий-  
хийг харсан тэр зүйлүүдээ хий хэмээжээ.

13 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, хэрэв та нар  
бүх зүрх сэтгэлээрээ Бурханы өмнө хоёр нүүр гаргах  
мөн мэхлэхийг үл үйлдэн, харин үнэн санаатайгаар  
Хүүг даган, нүглүүдээ наманчлан, Эцэгт та нар бап-  
тисмаар Христийн нэрийг өөрсдийн дээр авахад бэ-  
лэн байгаагаа гэрчлэн—тийм ээ, өөрсдийн Их Эзэн  
мөн өөрсдийн Аврагчийг усанд доош дагаж орвол,  
түүний үгийн дагуу, болгоогтун, чингээд та нар  
Ариун Сүнсийг хүлээн авах болно; тийм ээ, тэгээд  
галын мөн Ариун Сүнсний баптисм ирэх бөлгөө;  
мөн чингээд та нар тэнгэр элчүүдийн хэлээр ярьж,  
мөн Израилын Ариун Нэгэнд магтаалыг хашгиран  
хэлж чадахыг би мэднэ.

14 Гэвч, болгоогтун, хайрт ах дүү нар минь, Хүүгийн  
дуу хоолой надад тийн ирж, хэлсэн нь: Та нар нүг-  
лүүдээ наманчилж, мөн баптисм хүртсэнээр, миний  
зарлигуудыг сахихад бэлэн буйгаа Эцэгт гэрчилж,  
мөн Ариун Сүнсний мөн галын баптисм хүлээн авч,  
мөн шинэ хэлээр тийм ээ, бүр тэнгэр элчүүдийн хэ-  
лээр ярьж чадах болсныхоо дараа, мөн үүний дараа  
намайг үгүйсгэх аваас, намайг мэдэхгүй байсан нь та  
нарт дээр байх болно.

15 Мөн би Эцэгээс дуу хоолойг сонссон, өгүүлсэн нь:  
Тийм ээ, миний Хайртай нэгний үгс үнэн мөн ит-  
гэмжлэгдсэн бөлгөө. Эцсийг хүртэл тэвчсэн тэр нь,  
мөнхүү тэр нь аврагдах болно.

16 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, үүгээр хүмүүн  
амьд Бурханы Хүүгийн жишээг дагахдаа эцсээ хүр-  
тэл тэвчихээс бусдаар бол, тэр аврагдаж чадахгүйг би  
мэднэ.

And he said unto the children of men: Follow thou  
me. Wherefore, my beloved brethren, can we follow  
Jesus save we shall be willing to keep the command-  
ments of the Father?

And the Father said: Repent ye, repent ye, and be  
baptized in the name of my Beloved Son.

And also, the voice of the Son came unto me, saying:  
He that is baptized in my name, to him will the Father  
give the Holy Ghost, like unto me; wherefore, follow  
me, and do the things which ye have seen me do.

Wherefore, my beloved brethren, I know that if ye  
shall follow the Son, with full purpose of heart, acting  
no hypocrisy and no deception before God, but with  
real intent, repenting of your sins, witnessing unto the  
Father that ye are willing to take upon you the name of  
Christ, by baptism—yea, by following your Lord and  
your Savior down into the water, according to his word,  
behold, then shall ye receive the Holy Ghost; yea, then  
cometh the baptism of fire and of the Holy Ghost; and  
then can ye speak with the tongue of angels, and shout  
praises unto the Holy One of Israel.

But, behold, my beloved brethren, thus came the  
voice of the Son unto me, saying: After ye have repented  
of your sins, and witnessed unto the Father that ye are  
willing to keep my commandments, by the baptism of  
water, and have received the baptism of fire and of the  
Holy Ghost, and can speak with a new tongue, yea, even  
with the tongue of angels, and after this should deny  
me, it would have been better for you that ye had not  
known me.

And I heard a voice from the Father, saying: Yea, the  
words of my Beloved are true and faithful. He that en-  
dureth to the end, the same shall be saved.

And now, my beloved brethren, I know by this that  
unless a man shall endure to the end, in following the  
example of the Son of the living God, he cannot be  
saved.

17 Иймийн тул, та нарын Их Эзэн мөн та нарын Гэтэлгэгчийн хийхийг миний харсан та нарт миний хэлсэн тэр зүйлийг хий; учир нь та нар орох ёстой тэр хаалгаа мэдэж болохын тулд, энэ шалтгааны учир, тэдгээр нь надад үзүүлэгдсэн билээ. Тухайлбал та нарын орох ёстой хаалга нь наманчлал мөн усаар хийгдэх баптисм болой; мөн тэгээд Ариун Сүнсээр мөн галаар та нарын нүглүүдийн ангижрал ирэх бөлгөө.

18 Мөн чингээд та нар энэхүү мөнхийн амьдралд хүргэдэг давчуу бөгөөд нарийн замд байх болно; тийм ээ, та нар хаалгаар орсон бөлгөө; та нар Эцэг мөн Хүүгийн зарлигуудын дагуу хийсэн буюу; мөн хэрэв та нар уг замаар орвол та нар хүлээж авна хэмээн түүний өгсөн амлалт гүйцэлдэж, та нар Эцэг мөн Хүүг гэрчилдэг Ариун Сүнсийг хүлээж авсан билээ.

19 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нарыг энэ давчуу бөгөөд нарийн замд орсны дараа, бүгд хийгдсэн эсэхийг би асууя? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр даатган, түүнд хэлбэрэлтгүй итгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой.

20 Иймийн тул, та нар найдварын төгс гэрэлтэйгээр, мөн Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүлэх ёстой. Иймийн тул, хэрэв та нар урагш тэмүүлэн, Христийн үгнээс зооглон, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, Эцэгийн ийн хэлсэнчлэн: Та нарт мөнх амьдрал байх болно.

21 Мөн эдүгээ, болгоогтун, хайрт ах дүү нар минь, зам нь энэ; мөн хүмүүн Бурханы хаант улсад аврагдаж чадах өөр тийм өгөгдсөн нэр болон зам гэж тэнгэрийн дор үгүй. Мөн эдүгээ, болгоогтун, энэ нь Христийн сургаал мөн төгсгөлгүй нэг Бурхан болох Эцэгийн болон Хүүгийн, мөн Ариун Сүнсний үнэн бөгөөд цорын ганц сургаал болой. Амен.

Wherefore, do the things which I have told you I have seen that your Lord and your Redeemer should do; for, for this cause have they been shown unto me, that ye might know the gate by which ye should enter. For the gate by which ye should enter is repentance and baptism by water; and then cometh a remission of your sins by fire and by the Holy Ghost.

And then are ye in this strait and narrow path which leads to eternal life; yea, ye have entered in by the gate; ye have done according to the commandments of the Father and the Son; and ye have received the Holy Ghost, which witnesses of the Father and the Son, unto the fulfilling of the promise which he hath made, that if ye entered in by the way ye should receive.

And now, my beloved brethren, after ye have gotten into this strait and narrow path, I would ask if all is done? Behold, I say unto you, Nay; for ye have not come thus far save it were by the word of Christ with unshaken faith in him, relying wholly upon the merits of him who is mighty to save.

Wherefore, ye must press forward with a steadfastness in Christ, having a perfect brightness of hope, and a love of God and of all men. Wherefore, if ye shall press forward, feasting upon the word of Christ, and endure to the end, behold, thus saith the Father: Ye shall have eternal life.

And now, behold, my beloved brethren, this is the way; and there is none other way nor name given under heaven whereby man can be saved in the kingdom of God. And now, behold, this is the doctrine of Christ, and the only and true doctrine of the Father, and of the Son, and of the Holy Ghost, which is one God, without end. Amen.

## 2 Нифай 32

- 1 Мөн эдүгээ, болгоогтун, хайрт ах дүү нар минь, та нар уг замаар орсныхоо дараа та нар юу хийх ёстой талаараа зүрх сэтгэлдээ хэсэг зуур тунгааж буй хэмээн би сэтгэнэ. Гэвч, болгоогтун, та нар юуны учир эдгээр зүйлүүдийг зүрх сэтгэлдээ тунгаана вэ
- 2 Та нар Ариун Сүнс хүлээн авсныхаа дараа та нар тэнгэр элчүүдийн хэлээр ярьж чадна хэмээн миний хэлснийг та нар санахгүй байна уу? Мөн эдүгээ, Ариун Сүнсээр бус бөгөөс та нар яаж тэнгэр элчүүдийн хэлээр ярьж чадах билээ
- 3 Тэнгэр элчүүд Ариун Сүнсний хүчээр ярьдаг; иймийн тул, тэд Христийн үгсийг ярьдаг. Иймийн тул, би та нарт хэлсэнчлэн, Христийн үгэн дээр найрла, учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно.
- 4 Иймийн тул, эдүгээ би эдгээр үгсийг ярьсны дараа, хэрэв та нар эдгээрийг ойлгож эс чадах аваас энэ нь та нар асуудаггүй, бас тогшдоггүйн учир болой; иймийн тул, та нар гэрэлд авчрагдсангүй, харин харанхуйд мөхөх ёстой.
- 5 Учир нь болгоогтун, би та нарт дахин хэлье, хэрэв та нар уг замд орох, мөн Ариун Сүнсийг хүлээн авбаас, энэ нь та нарын хийвэл зохих тэр бүх зүйлийг та нарт үзүүлэх болно.
- 6 Болгоогтун, энэ нь Христийн сургаал, мөн тэрээр өөрийгөө та нарт бие махбодид үзүүлсний дарааг хүртэл ямар ч өөр сургаал өгөгдөхгүй байх болно. Мөн тэрээр өөрийгөө бие махбодид үзүүлэхэд, та нарт түүний хэлэх зүйлийг та нар хийхийг хичээгтүн.
- 7 Мөн эдүгээ би, Нифай, илүүг хэлж чадахгүй; Сүнс миний дууг зогсоож, мөн хүмүүний итгэлгүй, мөн ёсон бус, мөн үл мэдэх, мөн зөрүүдийн учир би гашуудан хоцрох буюу; учир нь мэдлэг тэдэнд тодорхой байдалд, бүр үгээр хэрхэн тодорхой байж болох тэр хэмжээгээр өгөгдөхөд тэд үүнийг үл эрэлхийлэн мөн агуу мэдлэгийг үл ойлгох авай.

## 2 Nephi 32

And now, behold, my beloved brethren, I suppose that ye ponder somewhat in your hearts concerning that which ye should do after ye have entered in by the way. But, behold, why do ye ponder these things in your hearts?

Do ye not remember that I said unto you that after ye had received the Holy Ghost ye could speak with the tongue of angels? And now, how could ye speak with the tongue of angels save it were by the Holy Ghost?

Angels speak by the power of the Holy Ghost; wherefore, they speak the words of Christ. Wherefore, I said unto you, feast upon the words of Christ; for behold, the words of Christ will tell you all things what ye should do.

Wherefore, now after I have spoken these words, if ye cannot understand them it will be because ye ask not, neither do ye knock; wherefore, ye are not brought into the light, but must perish in the dark.

For behold, again I say unto you that if ye will enter in by the way, and receive the Holy Ghost, it will show unto you all things what ye should do.

Behold, this is the doctrine of Christ, and there will be no more doctrine given until after he shall manifest himself unto you in the flesh. And when he shall manifest himself unto you in the flesh, the things which he shall say unto you shall ye observe to do.

And now I, Nephi, cannot say more; the Spirit stoppeth mine utterance, and I am left to mourn because of the unbelief, and the wickedness, and the ignorance, and the stiffneckedness of men; for they will not search knowledge, nor understand great knowledge, when it is given unto them in plainness, even as plain as word can be.

8 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, та нар зүрх сэтгэлдээ тунгаасаар буйг би ухамсарлаж байна; мөн би энэ зүйлийн талаар ярих ёстой болсон нь намайг гонсойлгож байна. Учир нь хэрэв та нар хүмүүнд залбирахыг сургах Сүнсийг анхааран аваас, та нар залбирах ёстойг мэдэх бөлгөө; өөрөөр хэлбэл хилэнцэт сүнс хүнд залбирахыг үл сургана, харин тэрээр залбирах ёсгүйг түүнд сургадаг.

9 Гэвч болгоогтун, та нар үргэлж залбирах ёстойг мөн шантрах ёсгүйг би та нарт хэлье; та нарын үйл бодгальд тань золтой байж болохын тулд тэр та нарын үйлийг та нарт ариулахын тулд юун түрүүнд та нар Христийн нэрээр Эцэгт залбирахаас өөр нэгээхэн ч зүйлийг Их Эзэнд үйлдэх ёсгүй.

And now, my beloved brethren, I perceive that ye ponder still in your hearts; and it grieveth me that I must speak concerning this thing. For if ye would hearken unto the Spirit which teacheth a man to pray, ye would know that ye must pray; for the evil spirit teacheth not a man to pray, but teacheth him that he must not pray.

But behold, I say unto you that ye must pray always, and not faint; that ye must not perform any thing unto the Lord save in the first place ye shall pray unto the Father in the name of Christ, that he will consecrate thy performance unto thee, that thy performance may be for the welfare of thy soul.

## 2 Нифай 33

- 1 Мөн эдүгээ би, Нифай, миний хүмүүсийн дунд сургагдсан бүх зүйлийг бичиж чадахгүй; бас би бичихдээ ярихынхаа адил бузгай нэгэн биш; учир нь хүн Ариун Сүнсний хүчээр ярихад Ариун Сүнсний хүч үүнийг хүмүүний үрсийн зүрх сэтгэлд хүргэдэг.
- 2 Гэвч болгоогтун, Ариун Сүнсний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулдаг нь олон буйн учир, энэ нь тэдэнд орших зайгүй болой; иймийн тул, тэд бичигдсэн тэдгээрээс олон зүйлийг хаяж мөн тэдгээрийг хоосон зүйлүүд мэт үнэлдэг болой.
- 3 Гэвч би, Нифай, өөрийн бичсэнийг бичсэн мөн энэ нь ялангуяа миний хүмүүст агуу чухал зүйл хэмээн би үнэлдэг. Учир нь би тэдний төлөө өдрөөр үргэлж залбиран мөн шөнөөр нүд минь дэрийг минь норгодог, тэдний учир болой; мөн би Бурхандаа итгэлтэйгээр гуйн залбирч, мөн тэр гуилтыг минь сонсохыг би мэднэ.
- 4 Мөн Их Эзэн Бурхан миний хүмүүсийн тусын тулд залбирлуудыг минь ариулан адислах болно гэдгийг би мэднэ. Мөн миний сул доройдоо бичсэн тэдгээр үгс тэдэнд хүчтэй болгогдох болно; учир нь энэ нь тэднийг сайныг хийхэд ятгадаг болой; энэ нь эцэг өвгөдийнх нь талаар тэдэнд мэдүүлдэг; мөн энэ нь Есүсийн тухай өгүүлж, мөн тэднийг түүнд итгэхийг, мөн мөнх амьдрал болох эцсийг хүртэл тэвчихийг ятгадаг бөлгөө.
- 5 Мөн энэ нь нүглийн эсрэг үнэний тодорхой байдлын дагуу, хатуугаар ярьдаг; иймийн тул, ямар ч хүмүүн, тэр нь чөтгөрийн сүнснийх байхаас гадуур бол миний бичсэн үгсэд уурлах нь үгүй болой.
- 6 Би тодорхой байдлыг бахаднам; би үнэнийг бахаднам; би өөрийн Есүсийг бахаднам, учир нь тэр бодгалийг минь тамаас гэтэлгэсэн билээ.
- 7 Би өөрийн хүмүүст энэрлийг, мөн би түүний шүүхийн суудалд толбогүйгээр олон сүнстэй уулзана хэмээн Христэд итгэх агуу итгэлийг агуулна.
- 8 Би Иудейд энэрлийг агуулна—би өөрийн ирсэн тэндээс тэднийг хамааруулан хэлж буй учир Иудей хэмээнэ би.

## 2 Nephi 33

And now I, Nephi, cannot write all the things which were taught among my people; neither am I mighty in writing, like unto speaking; for when a man speaketh by the power of the Holy Ghost the power of the Holy Ghost carrieth it unto the hearts of the children of men.

But behold, there are many that harden their hearts against the Holy Spirit, that it hath no place in them; wherefore, they cast many things away which are written and esteem them as things of naught.

But I, Nephi, have written what I have written, and I esteem it as of great worth, and especially unto my people. For I pray continually for them by day, and mine eyes water my pillow by night, because of them; and I cry unto my God in faith, and I know that he will hear my cry.

And I know that the Lord God will consecrate my prayers for the gain of my people. And the words which I have written in weakness will be made strong unto them; for it persuadeth them to do good; it maketh known unto them of their fathers; and it speaketh of Jesus, and persuadeth them to believe in him, and to endure to the end, which is life eternal.

And it speaketh harshly against sin, according to the plainness of the truth; wherefore, no man will be angry at the words which I have written save he shall be of the spirit of the devil.

I glory in plainness; I glory in truth; I glory in my Jesus, for he hath redeemed my soul from hell.

I have charity for my people, and great faith in Christ that I shall meet many souls spotless at his judgment-seat.

I have charity for the Jew—I say Jew, because I mean them from whence I came.

- 9 Би түүнчлэн харийханд энэрлийг агуулах болно. Гэвч болгоогтун, тэд Христэд нийцсэн байж, амьдралд хүргэх тэр нарийн хаалгаар орж мөн давчуу замаар алхан, мөн сорилтын өдрийн эцсийг хүртэл уг замыг үргэлжлүүлэхээс бусдаар бол би тэдгээрийн нэгээхний нь ч төлөө би найдаж чадахгүй бөлгөө.
- 10 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, мөн түүнчлэн Иудей, мөн дэлхийн өнцөг булан бүр та нар бүгд, эдгээр үгсийг анхааран сонсож мөн Христэд итгэ; мөн хэрэв та нар эдгээр үгсэд үл итгэх аваас, Христэд итгэ. Мөн хэрэв та нар Христэд итгэх болбоос та нар эдгээр үгсэд итгэх болно, учир нь эдгээр нь Христийн үгс, мөн тэрээр эдгээрийг надад өгсөн юм; мөн эдгээр нь тэд сайныг хийвэл зохихыг бүх хүмүүнд заадаг билээ.
- 11 Мөн хэрэв эдгээр нь Христийн үгс биш аваас, та нар шүүн тунгаа—өөрөөр хэлбэл Христ та нарт эцсийн өдөр, эдгээр нь түүний үгс гэдгийг агуу их сүр жавхлан хийгээд хүчээр үзүүлэх болно; мөн та нар болон би түүний тавцангийн өмнө нүүр нүүрээрээ тулан зогсох болно; мөн би сул дорой хэдий ч, эдгээр зүйлийг бичихийг би түүгээр зарлигдуулсныг та нар мэдэх болно.
- 12 Мөн би Христийн нэрээр Эцэгт, хэрэв бүгд бус бол, бидний олон нь тэрхүү агуу их хийгээд эцсийн өдөр, түүний хаант улсад аврагдаж болно хэмээн залбирдаг.
- 13 Мөн эдүгээ, хайрт ах дүү нар минь, Израилын угсааных болох тэд бүгд, мөн дэлхийн хязгаарууд та нар бүгд, би та нарт газар шорооноос хашгирах нэгний дуугаар: Тэр агуу их өдрийг ирэх хүртэл сайныг хүсье хэмээн хэлж байна.
- 14 Мөн Бурханы сайн сайхныг эс хүртэх, мөн иудейчүүдийн үгсийг, мөн түүнчлэн миний үгсийг, мөн Бурханы Хурганы амнаас гарах үгсийг үл хүндлэх та нар, болгоогтун, би та нарт үүрдийн хагацлын өмнө сайныг хүсье, учир нь эдгээр үгс эцсийн өдөр та нарыг буруутгах болно.
- 15 Учир нь дэлхий дээр миний лацадсан нь, шүүхийн тавцан дээр та нарын эсрэг авчрагдах болно; учир нь Их Эзэн надад тийн зарлигласан, мөн би дагах ёстой. Амен.

I also have charity for the Gentiles. But behold, for none of these can I hope except they shall be reconciled unto Christ, and enter into the narrow gate, and walk in the strait path which leads to life, and continue in the path until the end of the day of probation.

And now, my beloved brethren, and also Jew, and all ye ends of the earth, hearken unto these words and believe in Christ; and if ye believe not in these words believe in Christ. And if ye shall believe in Christ ye will believe in these words, for they are the words of Christ, and he hath given them unto me; and they teach all men that they should do good.

And if they are not the words of Christ, judge ye—for Christ will show unto you, with power and great glory, that they are his words, at the last day; and you and I shall stand face to face before his bar; and ye shall know that I have been commanded of him to write these things, notwithstanding my weakness.

And I pray the Father in the name of Christ that many of us, if not all, may be saved in his kingdom at that great and last day.

And now, my beloved brethren, all those who are of the house of Israel, and all ye ends of the earth, I speak unto you as the voice of one crying from the dust: Farewell until that great day shall come.

And you that will not partake of the goodness of God, and respect the words of the Jews, and also my words, and the words which shall proceed forth out of the mouth of the Lamb of God, behold, I bid you an everlasting farewell, for these words shall condemn you at the last day.

For what I seal on earth, shall be brought against you at the judgment bar; for thus hath the Lord commanded me, and I must obey. Amen.

# ИАКОВЫН НОМНИФАЙН ДҮҮ

*Ах нартаа номлосон түүний үгс оршвой. Тэрбээр Христийн сургаалыг сүйрүүлэхийг эрэлхийлэгч хүмүүнийг гутаав. Нифайн хүмүүсийн түүхийн талаарх хэдэн үг оршвой.*

## Иаков 1

- 1 УЧИР нь болгоогтун, улиран тохиох дор Лихай Иерусалимыг орхисон цагаас тавь бас таван жил улиран одов; иймийн тул, Иаков надад, эдгээр зүйлийг дээр нь сийлбэрлэсэн, жижиг ялтсуудын талаар зарлигийг Нифай өгсөн болой.
- 2 Мөн тэрбээр Иаков надад, би эдгээр ялтсууд дээр хамгийн үнэт байна хэмээн өөрийн эргэцүүлсэн зүйлүүдээс цөөн хэдийг нь бичвэл зохихыг, Нифайн хүмүүс гэж нэрлэгдсэн энэ хүмүүсийн түүхийн талаар өнгөцхөн дурдахаас бусдаар хүрч эс болохыг зарлигласан билээ.
- 3 Учир нь тэрбээр түүний хүмүүсийн түүх түүний бусад ялтсууд дээр сийлэгдсэн байвал зохихыг, мөн би эдгээр ялтсуудыг хадгалан үлдээж мөн тэднийг үр удамдаа үеэс үед гардуулан өгвөл зохихыг хэлсэн бөлгөө.
- 4 Мөн хэрэв ариун нандин гэгдсэн номлол, эсвээс агуу гэгдсэн илчлэлт, эсвэл бошиглол байх аваас, эдгээр ялтсууд дээр тэдгээрийн гол чухлыг нь сийлбэрлэн, мөн тэдгээрийн талаар аль болох ихийг Христийн тулд, мөн өөрсдийн хүмүүсийн тусын тулд тухайлан бичиглэхийг болой.
- 5 Өөрөөр хэлбэл итгэлийн мөн агуу зовнилын учир, бидэнд өөрсдийн хүмүүсийн талаар, тэдэнд чухам юу тохиолдох талаар үзүүлэгдсэн болой.
- 6 Мөн түүнчлэн бид олон илчлэлт, мөн их бошиглолын суу билигтэй байлаа; иймийн тул, ирэх ёстой Христийн, мөн түүний хаант улсын талаар бид мэдсэн билээ.

# The Book of Jacob

*The words of his preaching unto his brethren. He foundeth a man who seeketh to overthrow the doctrine of Christ. A few words concerning the history of the people of Nephi.*

## Jacob 1

For behold, it came to pass that fifty and five years had passed away from the time that Lehi left Jerusalem; wherefore, Nephi gave me, Jacob, a commandment concerning the small plates, upon which these things are engraven.

And he gave me, Jacob, a commandment that I should write upon these plates a few of the things which I considered to be most precious; that I should not touch, save it were lightly, concerning the history of this people which are called the people of Nephi.

For he said that the history of his people should be engraven upon his other plates, and that I should preserve these plates and hand them down unto my seed, from generation to generation.

And if there were preaching which was sacred, or revelation which was great, or prophesying, that I should engraven the heads of them upon these plates, and touch upon them as much as it were possible, for Christ's sake, and for the sake of our people.

For because of faith and great anxiety, it truly had been made manifest unto us concerning our people, what things should happen unto them.

And we also had many revelations, and the spirit of much prophecy; wherefore, we knew of Christ and his kingdom, which should come.



- 7 Иймийн тул тэд Израилын хүүхдүүдийг аглаг буйдад байхад уруу таталтын өдрүүдийн үеийн өдөөн хатгалтын адилаар тэд орох нь зохисгүй хэмээн өөрийн хилэгнэлд түүнийг зүхэх вий хэмээн Христэд ирж, мөн Бурханы сайн сайхныг хүртэж болно хэмээн, тэд түүний амралтад орж болно хэмээн бид тэднийг ухуулж болохын тулд, бид өөрсдийн хүмүүсийн дунд шаргуугаар хөдөлмөрлөсөн бөлгөө.
- 8 Иймийн тул, бид бүх хүмүүнийг, Бурханыг уурлуулахаар түүний эсрэг эсэргүүцэхгүй байхыг ятгаж чаддаг ч болоосой, харин бүх хүмүүн Христэд итгэж, мөн түүний үхлийг тунгааж, мөн түүний загалмайг үүрэлцэж бас дэлхийн шившгийг хуваалцаасай хэмээн Бурханд хандана; иймийн тул, би, Иаков, өөрийн ах Нифайнхаа зарлигийг биелүүлэхийг өөрийн биед хүлээх ажгуу.
- 9 Эдүгээ Нифай өндөр настай болж эхлэв, мөн тэрбээр өөрийгөө удахгүй наснаас халих ёстойг мэдэв; иймийн тул, тэрээр хаадын засаглалуудын дагуу, эдүгээ өөрийн хүмүүсийн дээр удирдагч мөн хаан байх хүнийг тослон адисалсан бөлгөө.
- 10 Хүмүүс Нифайг үлэмж хайрладаг байв, тэрбээр тэдэнд агуу өмгөөлөгч болж, тэднийг хамгаахын тулд Лебений илдийг эзэмшиж, мөн бүх өдрүүддээ тэдний тусын тулд хөдөлмөрлөж байсны учир бөлгөө.
- 11 Иймийн тул, хүмүүс түүний нэрийг санан хадгалах хүсэлтэй байв. Мөн түүний оронд засагласан хэн боловч хүмүүсээр, хоёрдугаар Нифай, гуравдугаар Нифай, мөн цаашлан, хаадын засаглалуудын дагуу нэрлэгдсэн ажээ; мөн тэдний нэр хэн байснаас үл хамааран, хүмүүсээр тэд тийн нэрлэгдсэн бөлгөө.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Нифай нас нөгчив.
- 13 Эдүгээ хүмүүс леменчүүд бус аваас нифайчууд гэгдэх болов; гэсэн хэдий ч тэд нифайчууд, иаковчууд, иосефчууд, зорамчууд, леменчүүд, лемүелчүүд, мөн ишмэйлчүүд хэмээн нэрлэгддэг байв.

Wherefore we labored diligently among our people, that we might persuade them to come unto Christ, and partake of the goodness of God, that they might enter into his rest, lest by any means he should swear in his wrath they should not enter in, as in the provocation in the days of temptation while the children of Israel were in the wilderness.

Wherefore, we would to God that we could persuade all men not to rebel against God, to provoke him to anger, but that all men would believe in Christ, and view his death, and suffer his cross and bear the shame of the world; wherefore, I, Jacob, take it upon me to fulfil the commandment of my brother Nephi.

Now Nephi began to be old, and he saw that he must soon die; wherefore, he anointed a man to be a king and a ruler over his people now, according to the reigns of the kings.

The people having loved Nephi exceedingly, he having been a great protector for them, having wielded the sword of Laban in their defence, and having labored in all his days for their welfare—

Wherefore, the people were desirous to retain in remembrance his name. And whoso should reign in his stead were called by the people, second Nephi, third Nephi, and so forth, according to the reigns of the kings; and thus they were called by the people, let them be of whatever name they would.

And it came to pass that Nephi died.

Now the people which were not Lamanites were Nephites; nevertheless, they were called Nephites, Jacobites, Josephites, Zoramites, Lamanites, Lemuelites, and Ishmaelites.

- 14 Харин би, Иаков, цаашид тэднийг эдгээр нэрүүдээр онцлохгүй, харин Нифайн хүмүүсийг устгахыг эрэлхийлэх тэднийг леменчүүд гэж нэрлэн, мөн Нифайд нөхөрсөг байдаг тэднийг нифайчууд, эсвээс Нифайн хүмүүс хэмээн нэрлэх болно, хаадын засаглалуудын дагуу болой.
- 15 Эдүгээ мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүс, хоёр дахь хааны засаглалын дор, зүрх сэтгэлдээ хатууг агуулж, мөн эртний Давид, мөн түүнчлэн түүний хүү Соломон нарын олон эхнэр болон татвар эмсийг хүссэнчлэн, ёсон бус дадлуудад өөрсдийгөө өөгшүүлж эхэлсэн бөлгөө.
- 16 Тийм ээ, мөн тэд түүнчлэн маш их алт болоод мөнгийг эрж эхлэв, мөн бардамналдаа зарим талаар ихэрхэх болж эхлэв.
- 17 Иймийн тул би, Иаков, эхлээд өөрийн даалгаврыг Их Эзэнээс аваад, ариун сүмд би тэдэнд сургахдаа эдгээр үгсийг тэдэнд өгсөн бөлгөө.
- 18 Учир нь би, Иаков, мөн миний дүү Иосеф, энэ хүмүүсийн санваартнууд хийгээд багш нар болж Нифайн гараар ариулан адислагдсан билээ.
- 19 Мөн бид Их Эзэнд өөрсдийн албан тушаалд хичээнгүйлэн зүтгэх, үүрэг хариуцлагыг өөрсдийн дээр авч, хэрэв бид тэдэнд бүх чадлаараа хичээнгүйлэн Бурханы үгийг заагаагүй аваас хүмүүний нүглийг толгой дээрээ хүлээх буюу; иймийн тул, өөрсдийн хүчээр хөдөлмөрлөснөөр тэдний цус бидний өмсгөл дээр ирэхгүй байж болох буюу; эс бөгөөс тэдний цус бидний өмсгөл дээр ирж, мөн бид эцсийн өдөр толбогүй байж эс чадах болно.

But I, Jacob, shall not hereafter distinguish them by these names, but I shall call them Lamanites that seek to destroy the people of Nephi, and those who are friendly to Nephi I shall call Nephites, or the people of Nephi, according to the reigns of the kings.

And now it came to pass that the people of Nephi, under the reign of the second king, began to grow hard in their hearts, and indulge themselves somewhat in wicked practices, such as like unto David of old desiring many wives and concubines, and also Solomon, his son.

Yea, and they also began to search much gold and silver, and began to be lifted up somewhat in pride.

Wherefore I, Jacob, gave unto them these words as I taught them in the temple, having first obtained mine errand from the Lord.

For I, Jacob, and my brother Joseph had been consecrated priests and teachers of this people, by the hand of Nephi.

And we did magnify our office unto the Lord, taking upon us the responsibility, answering the sins of the people upon our own heads if we did not teach them the word of God with all diligence; wherefore, by laboring with our might their blood might not come upon our garments; otherwise their blood would come upon our garments, and we would not be found spotless at the last day.

## Иаков 2

- 1 Нифайн дүү Иаков, Нифайг нас барсны дараа Нифайн хүмүүст ярьсан тэрхүү үгс оршвой.
- 2 Эдүгээ, хайрт ах дүү нар минь, Иаков, би, Бурханы өмнө хүлээсэн хариуцлагынхаа дагуу өөрийн албан тушаалд хичээнгүйлэн зүтгэж, мөн би өмсгөлөө та нарын нүглүүдээс ангижруулж болно хэмээн, би энэ өдөр та нарт Бурханы үгийг тунхаглаж болохын тулд ариун сүм өөд та нар дээр ирлээ.
- 3 Мөн би дуудлагынхаа албан тушаалд өдийг хүртэл хичээнгүй байсныг та нар өөрсдөө мэднэ; гэвч би энэ өдөр өдийг хүртэл байснаас үлэмж илүүгээр та нарын бодгалиудын аз жаргалын төлөө хүсэл тэмүүлэл хийгээд зовнилдоо дарагдан байна.
- 4 Учир нь болгоогтун, эдүгээ болтол, миний та нарт өгсөн, Их Эзэний үгэнд та нар дуулгавартай байсан билээ.
- 5 Гэвч болгоогтун, намайг анхааран сонсогтун, мөн тэнгэр болон газрыг Бүтээгч бүхнийг чадагч түүний тусламжаар та нарын бодлуудын талаар миний хувьд машид жигшүүрт гэгдэх, тийм ээ, мөн Бурханд ч жигшүүрт болох тэр нүгэлд та нар хэрхэн замнаж эхэлж байгааг би хэлж чадна.
- 6 Тийм ээ, зүрх сэтгэлийн тань ёсон бусын талаар би та нарт гэрчлэх ёстой болов, энэ нь миний сэтгэлийг гонсойлгож мөн өөрийн Бий Болгогчийн оршихуйн өмнө намайг ичсэнээс нугдайхад хүргэж байна.
- 7 Мөн түүнчлэн Бурханд таалагдах зүйл болох Бурханы өмнө олон нь үлэмж энхрий болоод ариун мөн эмзэг мэдрэмж бүхий тэдгээр эхнэр мөн хүүхдүүдийн чинь өмнө би та нарын талаарх яриандаа маш их шулууныг хэрэглэх ёстой болов, энэ нь намайг гонсойлгож байна.
- 8 Мөн тэд Бурханы таалалт үгийг сонсохоор нааш ирсэн хэмээн надад бодогдов, тийм ээ, шархадсан зүрх сэтгэлийг эдгээгч тэрхүү үгийг болой.

## Jacob 2

The words which Jacob, the brother of Nephi, spake unto the people of Nephi, after the death of Nephi:

Now, my beloved brethren, I, Jacob, according to the responsibility which I am under to God, to magnify mine office with soberness, and that I might rid my garments of your sins, I come up into the temple this day that I might declare unto you the word of God.

And ye yourselves know that I have hitherto been diligent in the office of my calling; but I this day am weighed down with much more desire and anxiety for the welfare of your souls than I have hitherto been.

For behold, as yet, ye have been obedient unto the word of the Lord, which I have given unto you.

But behold, hearken ye unto me, and know that by the help of the all-powerful Creator of heaven and earth I can tell you concerning your thoughts, how that ye are beginning to labor in sin, which sin appeareth very abominable unto me, yea, and abominable unto God.

Yea, it grieveth my soul and causeth me to shrink with shame before the presence of my Maker, that I must testify unto you concerning the wickedness of your hearts.

And also it grieveth me that I must use so much boldness of speech concerning you, before your wives and your children, many of whose feelings are exceedingly tender and chaste and delicate before God, which thing is pleasing unto God;

And it supposeth me that they have come up hither to hear the pleasing word of God, yea, the word which healeth the wounded soul.

- 9 Иймийн тул, тэдний шархыг эдгээж мөн тайтгаруулахын оронд, аль хэдийн шархалсан тэдгээрийн шархыг сэдрээх, та нарын гэмт хэргүүдийн дагуу та нарт сэрэмжлүүлэн сануулахаар, Бурханаас миний хүлээн авсан чанд зарлигийн учир, би албадуулах болсон нь зүрх сэтгэлийг минь хүндрүүлнэ; мөн шархлаагүй тэдэнд Бурханы таалалт үгсээс зооглохын оронд тэдний сүнсийг цоо хатгахаар мөн тэдний эмзэг оюуныг шархлуулахаар чинжаал хутгууд дүрэгдэх болой.
- 10 Гэвч, уг үүрэг агуу хэдий ч, би Бурханы чанд зарлигуудын дагуу үйлдэж мөн сэтгэлийн цэвэрт мөн харууссан зүрхэт тэдний дэргэд, мөн Бүхнийг Чадагч Бурханы цоо ширтэх мэлмийн харцан доор өөрсдийн чинь ёсон бус мөн жигшүүрт хэргүүдийн чинь талаар та нарт хэлэх ёстой.
- 11 Иймийн тул, Бурханы үгийн тодорхой байдлын дагуу би үнэнийг та нарт хэлэх ёстой. Учир нь болгоогтун, Их Эзэнээс хүссэний минь дагуу, уг үг надад ийн ирж, хэлсэн нь: Иаков, маргааш ариун сүм өөд яв, мөн чамд миний өгөх үгийг энэ хүмүүст тунхагла.
- 12 Мөн эдүгээ болгоогтун, ах дүү нар минь, та нарт миний тунхаглах тэрхүү үг энэ болой, та нарт болон та нарын үр удамд амлалтын нутаг болох тэр, энэхүү нутагт элбэг дэлбэгээр бялхах алт, мөн мөнгө, бас бүх төрлийн үнэт хүдрийг та нарын олонх нь эрж хайж эхэлсэн бөлгөө.
- 13 Мөн хангагч ариун мутар та нарын дээр ихэд тааламжтайгаар инээмсэглэж байсны учир та нар олон баялгийг эзэмшсэн билээ; мөн та нарын зарим нь ах дүүсээсээ илүү баялгийг эзэмшсэний учир та нар зүрх сэтгэлийн бардамналд өргөгдөж, мөн зөрүүдлэн дээгүүр хардаг учир нь та нарын өмсгөл чимэг үнэтэйн учир болой, мөн та нар өөрсдийгөө тэднээс илүү хэмээн бодох учир ах дүүсээ хавчих бөлгөө.
- 14 Мөн эдүгээ, ах дүүс минь, Бурхан та нарыг энэ зүйлд чинь зөвтгөнө хэмээн бодно уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй. Харин тэр та нарыг буруушаана, мөн хэрэв та нар эдгээр зүйлүүдэд энэ хэвээрээ үлдэх аваас түүний шүүлтүүд та нар дээр гэнэт ирэх ёстой.

Wherefore, it burdeneth my soul that I should be constrained, because of the strict commandment which I have received from God, to admonish you according to your crimes, to enlarge the wounds of those who are already wounded, instead of consoling and healing their wounds; and those who have not been wounded, instead of feasting upon the pleasing word of God have daggers placed to pierce their souls and wound their delicate minds.

But, notwithstanding the greatness of the task, I must do according to the strict commands of God, and tell you concerning your wickedness and abominations, in the presence of the pure in heart, and the broken heart, and under the glance of the piercing eye of the Almighty God.

Wherefore, I must tell you the truth according to the plainness of the word of God. For behold, as I inquired of the Lord, thus came the word unto me, saying: Jacob, get thou up into the temple on the morrow, and declare the word which I shall give thee unto this people.

And now behold, my brethren, this is the word which I declare unto you, that many of you have begun to search for gold, and for silver, and for all manner of precious ores, in the which this land, which is a land of promise unto you and to your seed, doth abound most plentifully.

And the hand of providence hath smiled upon you most pleasingly, that you have obtained many riches; and because some of you have obtained more abundantly than that of your brethren ye are lifted up in the pride of your hearts, and wear stiff necks and high heads because of the costliness of your apparel, and persecute your brethren because ye suppose that ye are better than they.

And now, my brethren, do ye suppose that God justifieth you in this thing? Behold, I say unto you, Nay. But he condemneth you, and if ye persist in these things his judgments must speedily come unto you.

- 15 Ай тэрбээр та нарыг цоо хатгаж, та нарыг мэл-  
мийнхээ ганц харцаар тоос болтол цохьж чадахаа  
тэрбээр үзүүлээсэй!
- 16 Ай тэрбээр та нарын энэ алдас мөн жигшүүрт хэр-  
гээс та нарыг ангижруулаасай. Мөн, Ай та нар түү-  
ний зарлигуудын үгийг сонсож, мөн та нарын зүрх-  
ний энэ бардамнал бодгалийг тань устгахыг бүү зөв-  
шөөрөөсэй!
- 17 Өөрсдийнхөө нэгэн адил ахан дүүсээ бод, мөн тэд  
та нарын адил баян байж болохын тулд бүгдтэй нө-  
хөрсөг, бас хөрөнгөөрөө өгөөмөр сэтгэлтэй бай.
- 18 Харин та нар баялгуудыг эрэлхийлэхийн өмнө,  
Бурханы хаант улсыг эрэлхийлэгтүн та нар.
- 19 Мөн та нар Христэд найдах найдварыг олсныхоо  
дараа хэрэв та нар тэдгээрийг эрэлхийлэх аваас, та  
нар баялгуудыг олох болно; мөн та нар тэдгээрийг  
сайныг үйлдэх зорилгын төлөө эрэлхийлэх болно—  
нүцгэнийг хувцаслахад, мөн өлссөнийг хооллоход,  
бас боолчлогдсоныг чөлөөлөхөд, мөн өвдсэн бас  
зовсныг халамжлахад буюу.
- 20 Мөн эдүгээ, ах дүү нар минь, би та нарт бардамна-  
лын талаар ярьсан болой; мөн та нарт Бурханы өг-  
сөн тэр зүйлүүдийн учир зүрхэндээ бардамналыг  
тээсэн учир хөршийгөө зовоож, мөн түүнийг хавч-  
сан та нар үүнийхээ талаар юу хэлэх билээ
- 21 Бүх маханбодийг бүтээсэн түүнд ийм зүйлүүд  
жигшүүртэй хэмээн та нар бодохгүй юу? Мөн түү-  
ний хувьд нэг нь бусдын адил эрхэм болой. Мөн бү-  
хий л маханбодь тоосных билээ; мөн тэрбээр тэд  
түүний зарлигуудыг дагаж мөн түүнийг үүрд алдар-  
шуулбал зохино гэсэн нэгэн адил зорилгын учир  
тэдгээрийг бүтээсэн ажгуу.
- 22 Мөн эдүгээ би энэхүү бардамналын талаар та нарт  
ярихаа төгсгөл болгоё. Мөн та нарт би үүнээс илүү  
жигшим гэмт хэргийн талаар ярих ёстой бус байсан  
аваас, миний зүрх сэтгэл та нарын учир үлэмж их ба-  
ясах сан.

O that he would show you that he can pierce you,  
and with one glance of his eye he can smite you to the  
dust!

O that he would rid you from this iniquity and  
abomination. And, O that ye would listen unto the  
word of his commands, and let not this pride of your  
hearts destroy your souls!

Think of your brethren like unto yourselves, and be  
familiar with all and free with your substance, that they  
may be rich like unto you.

But before ye seek for riches, seek ye for the kingdom  
of God.

And after ye have obtained a hope in Christ ye shall  
obtain riches, if ye seek them; and ye will seek them for  
the intent to do good—to clothe the naked, and to feed  
the hungry, and to liberate the captive, and administer  
relief to the sick and the afflicted.

And now, my brethren, I have spoken unto you con-  
cerning pride; and those of you which have afflicted  
your neighbor, and persecuted him because ye were  
proud in your hearts, of the things which God hath  
given you, what say ye of it?

Do ye not suppose that such things are abominable  
unto him who created all flesh? And the one being is as  
precious in his sight as the other. And all flesh is of the  
dust; and for the selfsame end hath he created them,  
that they should keep his commandments and glorify  
him forever.

And now I make an end of speaking unto you con-  
cerning this pride. And were it not that I must speak  
unto you concerning a grosser crime, my heart would  
rejoice exceedingly because of you.

23 Гэвч та нарын илүү жигшим хэргүүдийн учир Бурханы үг намайг шаналгана. Учир нь болгоогтун, ийн Их Эзэн хэлэв: Энэ хүмүүс ёсон бусад уусч эхэлжээ; тэд судруудыг ойлгодоггүй, өөрөөр хэлбэл тэд шалиг завхайг үйлдэхдээ өөрсдийгөө зөвтгөхөөр эрэлхийлдэг, Давид мөн түүний хүү Соломоны талаар бичигдсэн байгаа тэдгээр зүйлүүдийн учир бөлгөө.

24 Болгоогтун, Давид Соломон хоёр үнэхээр олон эхнэр мөн татвар эмстэй байсан нь миний өмнө жигшүүрт зүйл болой хэмээн Их Эзэн хэлэв.

25 Иймийн тул, Их Эзэн ийн хэлэв, би өөртөө Иосефын хэвлийн үрээс зөв шударга мөчрийг өсгөж болохын тулд би энэ хүмүүсийг өөрийн гараар Иерусалим газраас гаргаж удирдсан билээ.

26 Иймийн тул, Их Эзэн Бурхан бибээр энэ хүмүүс эрт цагийн тэдэнтэй адил үйлдэхийг тэвчихгүй.

27 Иймийн тул, ах дүүс минь, намайг сонсогтун, мөн Их Эзэний үгийг анхаарцгаа: Өөрөөр хэлбэл та нарын дунд хэн боловч нэгээс илүү эхнэртэй байж үл болно; мөн тэрбээр татвар эмс нэгийг ч авах ёсгүй.

28 Учир нь би, Их Эзэн Бурхан, эмэгтэйчүүдийн ариун явдалд баясдаг билээ. Мөн завхайрал нь миний өмнө жигшүүрт хэрэг; тийн Түмний Их Эзэн хэлдэг бөлгөө.

29 Иймийн тул, энэ хүмүүс миний зарлигуудыг дагах болно хэмээн Түмний Их Эзэн хэлэв, эсвээс уг нутаг тэдний үйлүүдийн улмаас зүхэгдэг.

30 Учир нь хэрэв би, Түмний Их Эзэн, надад үр удмыг өсгөхийг хүсвэл, би өөрийн хүмүүст зарлиглах болно; өөрөөр бол тэд эдгээр зүйлийг анхааран сонсох болно хэмээн хэлэв.

31 Учир нь болгоогтун, би, Их Эзэн, Иерусалимын газарт, тийм ээ, мөн миний хүмүүсийн бүх нутгуудад, тэд эр нөхрүүдийнхээ ёсон бус хийгээд жигшүүрт хэргүүдийн улмаас миний хүмүүсийн охидын гашуудахыг сонсож, бас харамсахыг нь харсан билээ.

32 Мөн, Түмний Их Эзэн, би бээр Иерусалимын газраас удирдан гаргасан тэдгээр болох энэ хүмүүсийн хонгорхон охидын уйлааныг, миний хүмүүсийн эрчүүдийн эсрэг дээш надад ирэхийг би зөвшөөрөхгүй хэмээн Түмний Их Эзэн хэлэв.

But the word of God burdens me because of your grosser crimes. For behold, thus saith the Lord: This people begin to wax in iniquity; they understand not the scriptures, for they seek to excuse themselves in committing whoredoms, because of the things which were written concerning David, and Solomon his son.

Behold, David and Solomon truly had many wives and concubines, which thing was abominable before me, saith the Lord.

Wherefore, thus saith the Lord, I have led this people forth out of the land of Jerusalem, by the power of mine arm, that I might raise up unto me a righteous branch from the fruit of the loins of Joseph.

Wherefore, I the Lord God will not suffer that this people shall do like unto them of old.

Wherefore, my brethren, hear me, and hearken to the word of the Lord: For there shall not any man among you have save it be one wife; and concubines he shall have none;

For I, the Lord God, delight in the chastity of women. And whoredoms are an abomination before me; thus saith the Lord of Hosts.

Wherefore, this people shall keep my commandments, saith the Lord of Hosts, or cursed be the land for their sakes.

For if I will, saith the Lord of Hosts, raise up seed unto me, I will command my people; otherwise they shall hearken unto these things.

For behold, I, the Lord, have seen the sorrow, and heard the mourning of the daughters of my people in the land of Jerusalem, yea, and in all the lands of my people, because of the wickedness and abominations of their husbands.

And I will not suffer, saith the Lord of Hosts, that the cries of the fair daughters of this people, which I have led out of the land of Jerusalem, shall come up unto me against the men of my people, saith the Lord of Hosts.

33 Учир нь номхон сайхных нь улмаас тэд миний хүмүүсийн охидыг олзлон хөглөхгүй, тэгвэл би тэдэнд зовлонг зүхлээр, бүр устгалд хүргэх түүгээр айлчлах болно; учир нь тэд садар самууныг эрт цагийн тэдний адил үйлдэх ёсгүй, хэмээн Түмний Их Эзэн хэлэв.

34 Мөн эдүгээ болгоогтун, ах дүүс минь, эдгээр зарлигууд бидний эцэг Лихайд өгөгдсөнийг та нар мэднэ; иймийн тул, та нар тэдгээрийг урьд нь мэддэг байв; мөн та нар агуу буруутгалд унасан бөлгөө; учир нь та нар хийх нь зохисгүй зүйлийг үйлдсэн бөлгөө.

35 Болгоогтун, та нар өөрсдийн ах дүүс болох леменчүүдээс илүүтэй алдсыг үйлдсэн бөлгөө. Та нар цэвэр эмзэг эхнэрүүдийнхээ зүрхийг эмтэлж, мөн тэдний өмнө өөрсдийн муу жишээнүүдийн учир, хүүхдүүдийнхээ итгэлийг алдсан; мөн тэдний зүрхний мэгшилтүүд та нарын эсрэг Бурхан өөд дээш ирж байна. Мөн та нарын эсрэг доош ирэх Бурханы үг шулууны учир олон бодгаль гүнзгий шархнуудаас цоорч үхсэн билээ.

For they shall not lead away captive the daughters of my people because of their tenderness, save I shall visit them with a sore curse, even unto destruction; for they shall not commit whoredoms, like unto them of old, saith the Lord of Hosts.

And now behold, my brethren, ye know that these commandments were given to our father, Lehi; wherefore, ye have known them before; and ye have come unto great condemnation; for ye have done these things which ye ought not to have done.

Behold, ye have done greater iniquities than the Lamanites, our brethren. Ye have broken the hearts of your tender wives, and lost the confidence of your children, because of your bad examples before them; and the sobbings of their hearts ascend up to God against you. And because of the strictness of the word of God, which cometh down against you, many hearts died, pierced with deep wounds.

## Иаков 3

- 1 Гэвч болгоогтун, Иаков, би, зүрх сэтгэлээрээ цэвэр байх та нарт ярихыг хүснэ. Бурханд шийдэмгий оюунаар хандаж, мөн түүнд үлэмж итгэлтэйгээр залбирагтун, мөн тэрбээр та нарыг зовлонд чинь тайтгаруулна, мөн тэрбээр та нарыг өмгөөлж, мөн та нарын устгалыг эрэлхийлэх тэдэнд шударга ёсыг доош илгээх болно.
- 2 Ай цэвэр зүрх сэтгэлтэй болох та нар бүгд, тэргүүнээ өргөгтүн, мөн Бурханы таалалт үгийг хүлээн авагтун, түүний хайран дээр найрлагтун; учир нь та нар, хэрэв та нарын оюун шийдэмгий аваас, үүрд түүнчлэн байх болно.
- 3 Гэвч зүрх сэтгэл цэвэр бус, энэ өдөр Бурханы өмнө бузар байгаа та нарт халаг, ай халаг; учир нь та нар наманчлахгүй аваас уг нутаг та нарын улмаас зүхэгдэх болно; мөн, та нарын адил бузар бус, гэсэн хэдий ч зовлонт зүхлээр зүхэгдсэн Леменчүүд, та нарыг бүр усталд чинь хүртэл цээрлүүлэх болно.
- 4 Мөн та нар наманчлахгүй аваас тэд та нарын өвлөсөн нутгийг эзэмшиж мөн Их Эзэн Бурхан та нарын дундаас зөв шударгыг үйлдэгчдийг зайлуулан гаргаж удирдах тэр цаг удахгүй ирэх болно.
- 5 Болгоогтун, тэдний бузрынх нь мөн тэдний арьсанд ирсэн тэр зүхлийн учир та нарын үзэн яддаг, та нарын ахан дүүс болох тэдгээр леменчүүд, та нараас илүү зөв шударга; учир нь бидний эцэгт өгөгдсөн, тэд нэг эхнэртэй байх мөн тэд нэгээхэн ч тагвар эмс авахгүй, мөн тэдний дунд завхайрал үйлдэгдэх ёсгүй хэмээх Их Эзэний зарлигийг тэд мартаагүй юм.
- 6 Мөн эдүгээ, энэ зарлигийг дагахын төлөө тэд чармайдаг; иймийн тул, зарлигийг дагах энэхүү чармайлын учир, Их Эзэн Бурхан тэднийг устгахгүй, харин тэдэнд нигүүлсэнгүй байх болно; мөн нэгэн өдөр тэд адислагдсан хүмүүс болно.

## Jacob 3

But behold, I, Jacob, would speak unto you that are pure in heart. Look unto God with firmness of mind, and pray unto him with exceeding faith, and he will console you in your afflictions, and he will plead your cause, and send down justice upon those who seek your destruction.

O all ye that are pure in heart, lift up your heads and receive the pleasing word of God, and feast upon his love; for ye may, if your minds are firm, forever.

But, wo, wo, unto you that are not pure in heart, that are filthy this day before God; for except ye repent the land is cursed for your sakes; and the Lamanites, which are not filthy like unto you, nevertheless they are cursed with a sore cursing, shall scourge you even unto destruction.

And the time speedily cometh, that except ye repent they shall possess the land of your inheritance, and the Lord God will lead away the righteous out from among you.

Behold, the Lamanites your brethren, whom ye hate because of their filthiness and the cursing which hath come upon their skins, are more righteous than you; for they have not forgotten the commandment of the Lord, which was given unto our father—that they should have save it were one wife, and concubines they should have none, and there should not be whoredoms committed among them.

And now, this commandment they observe to keep; wherefore, because of this observance, in keeping this commandment, the Lord God will not destroy them, but will be merciful unto them; and one day they shall become a blessed people.



- 7 Болгоогтун, тэдний эр нөхрүүд эхнэрээ хайрладаг, мөн тэдний эхнэрүүд эр нөхрөө хайрладаг; мөн тэдний эр нөхрүүд мөн тэдний эхнэрүүд хүүхдүүдээ хайрладаг; мөн тэдний итгэлгүй байдал, бас тэд та нарт хонзогнох нь эцэг өвгөдийнх нь алдсын улмаас бөлгөө; иймийн тул өөрсдийнхөө агуу их Бүтээгчийн мэлмийд та нар тэднээс яахан илүү дээр байх билээ
- 8 Ай ах дүү нар минь, та нар нүглүүдээ наманчлахгүй болбоос та нар тэдэнтэй хамт Бурханы сэнтийн өмнө аваачигдах үед, тэдний арьс та нарынхаас илүү цагаан байх вий хэмээн би айнам.
- 9 Иймийн тул, Бурханы үг болох, миний та нарт өгөх зарлиг бол та нар тэдний арьс барааны улмаас тэднийг дахин эсэргүүцэн бүү доромжил; бас та нар тэдний бузрын учир тэднийг бүү эсэргүүцэн доромжил; харин та нар өөрсдөө өөрсдийнхөө бузар явдлыг санаж, мөн тэдний бузар явдал эцэг өвгөдийнх нь улмаас ирснийг сана.
- 10 Иймийн тул, та нар хүүхдүүдээ, тэдний өмнө та нарын үзүүлсэн жишээний учир зүрх сэтгэлийг нь та нар хэрхэн гонсойлгож буйгаа санах болно; мөн түүнчлэн, бузар явдлуудынхаа учир, хүүхдүүдээ устгалд авчирч, мөн тэдний нүглүүд эцсийн өдөр та нарын толгой дээр овоорч магадгүйг сана та нар.
- 11 Ай ах дүү нар минь, миний үгсийг сонсогтун; бодгалийнхаа чадварыг сэргээ; та нар үхлийн нойрноос сэргж болохын тулд өөрсдийгөө сэгсэрцгээ; мөн хоёр дахь үхэл болох хүхэрт чулуун болон галт нуурт хаягдаж, чөтгөрийн элчүүд болохгүйн тулд өөрсдийгөө тамын тарчлалаас салга.
- 12 Мөн эдүгээ, Иаков, би, Нифайн хүмүүст илүү олон зүйлийг ярьж, хууль бусаар эр эм бололцох хийгээд тачаал, бас нүглийн зүйл болгоны эсрэг тэдэнд сануулж, тэдгээрийн аймшигт хор уршгийг тэдэнд хэллээ.
- 13 Мөн энэ хүмүүсийн эдүгээ тоолшгүй болж байгаа үйл хэргүүдийн зууны нэг хэсэг нь эдгээр ялтсууд дээр бичигдэж чадахгүй; гэвч тэдний хэргүүдээс олон нь мөн тэдний дайнууд, мөн тэдний тэмцлүүд, мөн тэдний хаадын засаглалууд илүү том ялтсууд дээр бичигдсэн буй.

Behold, their husbands love their wives, and their wives love their husbands; and their husbands and their wives love their children; and their unbelief and their hatred towards you is because of the iniquity of their fathers; wherefore, how much better are you than they, in the sight of your great Creator?

O my brethren, I fear that unless ye shall repent of your sins that their skins will be whiter than yours, when ye shall be brought with them before the throne of God.

Wherefore, a commandment I give unto you, which is the word of God, that ye revile no more against them because of the darkness of their skins; neither shall ye revile against them because of their filthiness; but ye shall remember your own filthiness, and remember that their filthiness came because of their fathers.

Wherefore, ye shall remember your children, how that ye have grieved their hearts because of the example that ye have set before them; and also, remember that ye may, because of your filthiness, bring your children unto destruction, and their sins be heaped upon your heads at the last day.

O my brethren, hearken unto my words; arouse the faculties of your souls; shake yourselves that ye may awake from the slumber of death; and loose yourselves from the pains of hell that ye may not become angels to the devil, to be cast into that lake of fire and brimstone which is the second death.

And now I, Jacob, spake many more things unto the people of Nephi, warning them against fornication and lasciviousness, and every kind of sin, telling them the awful consequences of them.

And a hundredth part of the proceedings of this people, which now began to be numerous, cannot be written upon these plates; but many of their proceedings are written upon the larger plates, and their wars, and their contentions, and the reigns of their kings.

14 Эдгээр ялтсууд Иаковын ялтсууд хэмээн нэрлэгдэж, мөн тэдгээр нь Нифайн гараар хийгдсэн бөлгөө. Мөн би эдгээр үгсийг ярихаа төгсгөл болгоё.

These plates are called the plates of Jacob, and they were made by the hand of Nephi. And I make an end of speaking these words.

## Иаков 4

- 1 Эдүгээ болгоогтун, улиран тохиох дор, Иаков, би, өөрийн хүмүүсийг үгэнд ихэд тохинуулсан, (мөн өөрсдийн үгсийг ялтсууд дээр сийлбэрлэхэд бэрхийн учир, би өөрийн үгсээс багахнаас бусдыг бичиж чадахгүй) мөн бид ялтсууд дээр бичсэн уг зүйлүүд хадгалагдан үлдэх ёстойг мэднэ;
- 2 Гэвч ялтсууд дээрхээс бусад бидний бичсэн зүйлүүд юу ч байсан эрсдэж мөн алга болох учиртай; харин хүүхдүүддээ, мөн түүнчлэн хайрт ах дүү нартаа, бидний талаар эсвээс тэдний эцэг өвгөдийн талаарх мэдлэгийн бяцхан хэсгийг өгөх цөөн үгийг ялтсууд дээр бид бичиж чадна—
- 3 Эдүгээ энэ зүйлд бид баясна; мөн бидний хайрт ах дүү нар болон хүүхдүүд маань тэдгээрийг талархсан сэтгэлээр хүлээн авна, мөн тэд харамсалгүйгээр бас зэвүүцэлгүйгээр харин баясгалантайгаар анхны эцэг эхийнхээ талаар мэдэж болох учир тэдгээрийг харах буюу хэмээн найдаж, эдгээр үгсийг ялтсууд дээр сийлэхээр бид хичээнгүйлэн хөдөлмөрлөж буй бөлгөө.
- 4 Учир нь, бид Христийг мэдсэн, мөн түүнийг ирэхээс олон зуун жилийн өмнө түүний сүр жавхланг хүлээн авах найдлага бидэнд байсныг тэд мэдэж болно хэмээн, бид эдгээр зүйлийг энэ зорилтын учир бичиглэсэн болой; мөн зөвхөн бид ч бус, харин биднээс өмнө байсан бүх ариун бошиглогчид түүнчлэн түүний сүр жавхланд найдаж байсан ажээ.
- 5 Болгоогтун, тэд Христэд итгэж мөн түүний нэрээр Эцэгийг шүтэн биширч байв, мөн бид түүнчлэн түүний нэрээр Эцэгийг шүтэн биширдэг бөлгөө. Мөн энэ зорилтын учир бид Мосегийн хуулийг дагадаг, энэ нь бидний сэтгэл зүрхийг түүнд хандуулдаг; мөн энэ шалтгааны улмаас энэ нь зөв шударга ёсны төлөө биднийг ариулсан, бүр энэ нь Бурхан болон түүний Төрсөн Ганц Хүүгийн дүрслэл болох аглаг буйдад Абрахам Бурханы зарлигуудад дуулгавартай байхын тулд хүү Исаакаараа тахил өргөх гэсний шалтгаан байсан бөлгөө.

## Jacob 4

Now behold, it came to pass that I, Jacob, having ministered much unto my people in word, (and I cannot write but a little of my words, because of the difficulty of engraving our words upon plates) and we know that the things which we write upon plates must remain;

But whatsoever things we write upon anything save it be upon plates must perish and vanish away; but we can write a few words upon plates, which will give our children, and also our beloved brethren, a small degree of knowledge concerning us, or concerning their fathers—

Now in this thing we do rejoice; and we labor diligently to engraven these words upon plates, hoping that our beloved brethren and our children will receive them with thankful hearts, and look upon them that they may learn with joy and not with sorrow, neither with contempt, concerning their first parents.

For, for this intent have we written these things, that they may know that we knew of Christ, and we had a hope of his glory many hundred years before his coming; and not only we ourselves had a hope of his glory, but also all the holy prophets which were before us.

Behold, they believed in Christ and worshiped the Father in his name, and also we worship the Father in his name. And for this intent we keep the law of Moses, it pointing our souls to him; and for this cause it is sanctified unto us for righteousness, even as it was accounted unto Abraham in the wilderness to be obedient unto the commands of God in offering up his son Isaac, which is a similitude of God and his Only Begotten Son.

6 Иймийн тул, бид бошиглогчдыг судалж байв, мөн бидэнд олон илчлэлт болон бошиглолын суу билиг байв; мөн бид эдгээр олон нотолгоотой болсон учир найдлага олж, мөн итгэл маань гуйвшгүй болно, үүний хэрээр бид Есүсийн нэрээр зарлиглаж чадаад мөн модод, бас уулс, бас далайн давалгаа бидэнд дуулгавартай байв.

7 Гэсэн хэдий ч, энэ нь түүний ач ивээл мөн хүмүүний үрсэд хандах түүний агуу их хүлцлээр бид эдгээр зүйлийг хийх хүчтэй гэдгийг бид мэдэж болохын тулд Их Эзэн Бурхан өөрсдийн маань сул доройг бидэнд үзүүлдэг болой.

8 Болгоогтун, Их Эзэний ажлууд агуу хийгээд гайхамшигтай юм. Түүний нууцуудын гүн нь хичнээн танигдашгүй билээ; мөн хүмүүн түүний бүхий л замуудыг олж мэдэх нь боломжгүй. Мөн түүнд илчлэгдээгүй аваас ямар ч хүмүүн түүний замуудыг үл мэднэ; иймийн тул, ахан дүүс минь, Бурханы илчлэлтүүдийг бүү басамжил.

9 Учир нь болгоогтун, дэлхийн гадаргуу дээр хүмүүн түүний үгийн хүчээр ирсэн юм, түүний үгийн хүчээр бүтээгдсэн тэрхүү дэлхийд шүү дээ. Иймийн тул, хэрэв Бурхан яриад дэлхийг тогтоож, бас яриад мөн хүмүүнийг бүтээж чадсан атал, Ай тэгвэл, яахан өөрийн зорилго мөн тааллын дагуу газар дэлхийд, эсвээс үүний гадаргуу дээрх мутрынхаа бүтээлд зарлиглаж чадахгүй байх билээ

10 Иймийн тул, ах дүүс минь, Их Эзэнд зөвлөхөөр бус, харин түүний мутраас зөвлөгөөг авахаар эрэлхийл. Учир нь болгоогтун, тэрбээр мэргэн ухаанд, мөн шударга ёсонд, мөн агуу их нигүүлсэлд, өөрийн бүх ажлыг хамруулан зөвлөдгийг та нар өөрсдөө мэддэг шүү дээ.

11 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, түүний Төрсөн Ганц Хүү, Христийн цагаатгалаар түүнд нийцсэн бай, тэгвэл Христэд байх амилуулалтын хүчээр та нар амилуулалтыг олж болно, мөн итгэлтэй байж, мөн түүнийг бие махбодид өөрийгөө үзүүлэхээс өмнө түүний сүр жавхлангийн сайн найдлагыг олж, мөн Бурханд Христийн анхны үр жимс хэмээн танилцуулагдах бөлгөө.

Wherefore, we search the prophets, and we have many revelations and the spirit of prophecy; and having all these witnesses we obtain a hope, and our faith becometh unshaken, insomuch that we truly can command in the name of Jesus and the very trees obey us, or the mountains, or the waves of the sea.

Nevertheless, the Lord God showeth us our weakness that we may know that it is by his grace, and his great condescensions unto the children of men, that we have power to do these things.

Behold, great and marvelous are the works of the Lord. How unsearchable are the depths of the mysteries of him; and it is impossible that man should find out all his ways. And no man knoweth of his ways save it be revealed unto him; wherefore, brethren, despise not the revelations of God.

For behold, by the power of his word man came upon the face of the earth, which earth was created by the power of his word. Wherefore, if God being able to speak and the world was, and to speak and man was created, O then, why not able to command the earth, or the workmanship of his hands upon the face of it, according to his will and pleasure?

Wherefore, brethren, seek not to counsel the Lord, but to take counsel from his hand. For behold, ye yourselves know that he counseleth in wisdom, and in justice, and in great mercy, over all his works.

Wherefore, beloved brethren, be reconciled unto him through the atonement of Christ, his Only Begotten Son, and ye may obtain a resurrection, according to the power of the resurrection which is in Christ, and be presented as the first-fruits of Christ unto God, having faith, and obtained a good hope of glory in him before he manifesteth himself in the flesh.

12 Мөн эдүгээ, хайрлагдсан та нар, би эдгээр зүйлийг та нарт хэлж байгаад бүү гайхагтун; өөрөөр хэлбэл яагаад амилуулалтын мөн ирэх ертөнцийн мэдлэгт хамаарах Христийн цагаатгалыг ярихгүй мөн түүний төгс мэдлэгт хүрэхгүй байх билээ

13 Болгоогтун, ах дүү нар минь, бошиглох тэрээр, хүмүүний ойлголтын тулд бошиглог; өөрөөр хэлбэл Сүнс хуурах нь үгүй, мөн үнэнийг хэлдэг. Иймийн тул, энэ нь үнэхээр тэдгээр зүйлүүдийг байгаагаар нь, мөн тэдгээр зүйлүүдийг үнэхээр байхаар нь ярьдаг; иймийн тул, эдгээр зүйлүүд, бидний бодгалиудын авралын тулд бидэнд тодорхой үзүүлэгдсэн, билээ. Гэвч болгоогтун, зөвхөн бид эдгээр зүйлүүдийг гэрчилж байгаа бус; учир нь Бурхан түүнчлэн эртний бошиглогчдод тэдгээрийг ярьсан бөлгөө.

14 Гэвч болгоогтун, иудейчүүд зөрүүд хүмүүс байв; мөн тэд тодорхой байдлын үгсийг басамжилсан билээ; мөн бошиглогчдыг алсан, мөн тэд ойлгож чадаагүй зүйлүүдийнхээ төлөө эрэлхийлсэн юм. Иймийн тул, уг зорилгоос алсуур хайснаас болсон тэр, харалганыхаа учир тэд унах ёстой нь зайлшгүй; өөрөөр хэлбэл Бурхан тэднээс өөрийн тодорхой байдлыг зайлуулан авч, мөн тэдний ойлгож чадахгүй тэрхүү олон зүйлийг тэдэнд илгээсэн ажээ, тэд үүнийг хүссэний учир буюу. Мөн тэд үүнийг хүссэн учир Бурхан үүнийг тэд бүдэрч болохын тулд хийсэн ажгуу.

15 Мөн эдүгээ би, Иаков, бошиглолд Сүнсээр удирдагдан байв; өөрөөр хэлбэл надад байх тэрхүү Сүнсний нөлөөгөөр иудейчүүдийн бүдрэлийн улмаас, тэд дээр нь барьж болох чулуунаас мөн аюулгүй суурьтай байхаас татгалзах болно гэдгийг би ухаарч мэдсэн болой.

16 Гэвч болгоогтун, судруудын дагуу, энэ чулуу нь иудейчүүд дээр нь барьж чадах тэр агуу их, мөн сүүлийн мөн цорын ганц тогтвортой суурь юм.

17 Мөн эдүгээ, хайрт та нар минь, энэ нь булангийн тулгуур болох магадгүй тэр тогтвортой сууринаас татгалзсаны дараа яаж үүн дээр барих боломжтой байх билээ

And now, beloved, marvel not that I tell you these things; for why not speak of the atonement of Christ, and attain to a perfect knowledge of him, as to attain to the knowledge of a resurrection and the world to come?

Behold, my brethren, he that prophesieth, let him prophesy to the understanding of men; for the Spirit speaketh the truth and lieth not. Wherefore, it speaketh of things as they really are, and of things as they really will be; wherefore, these things are manifested unto us plainly, for the salvation of our souls. But behold, we are not witnesses alone in these things; for God also spake them unto prophets of old.

But behold, the Jews were a stiffnecked people; and they despised the words of plainness, and killed the prophets, and sought for things that they could not understand. Wherefore, because of their blindness, which blindness came by looking beyond the mark, they must needs fall; for God hath taken away his plainness from them, and delivered unto them many things which they cannot understand, because they desired it. And because they desired it God hath done it, that they may stumble.

And now I, Jacob, am led on by the Spirit unto prophesying; for I perceive by the workings of the Spirit which is in me, that by the stumbling of the Jews they will reject the stone upon which they might build and have safe foundation.

But behold, according to the scriptures, this stone shall become the great, and the last, and the only sure foundation, upon which the Jews can build.

And now, my beloved, how is it possible that these, after having rejected the sure foundation, can ever build upon it, that it may become the head of their corner?

18      Болгоогтун, хайрт ах дүү нар минь, энэ нууцыг би  
та нарт дэлгэе; хэрэв ямар нэгэн шалтгаанаар би,  
Сүнсэн дэх өөрийн шийдэмгий байдлаас ухрахгүй,  
мөн та нарын төлөөх үлэмж зовнилынхоо учир бүд-  
рэхгүй аваас буюу.

Behold, my beloved brethren, I will unfold this mys-  
tery unto you; if I do not, by any means, get shaken  
from my firmness in the Spirit, and stumble because of  
my over anxiety for you.

## Иаков 5

- 1 Болгоогтун, ах дүү нар минь, Израилын угсаанд түүний ярьсан бошиглогч Зиносын үгсийг уншсанаа та нар санахгүй байна уу, өгүүлсэн нь:
- 2 Анхаарагтун, Ай Израилын угсаа та нар, мөн Их Эзэний бошиглогч, миний үгсийг сонс.
- 3 Учир нь болгоогтун, Их Эзэн ийн хэлжээ, Ай Израилын угсаа, би чамайг усан үзмийн талбайдаа нэгэн хүний авч арчилсан, чидуны таримал модтой адилтгана; мөн энэ нь ургаж, мөн өтлөөд, мөн өмхөрч эхэлсэн буюу.
- 4 Мөнхүү улиран тохиох дор талбайн эзэн гарч, мөн тэрээр чидуны мод өмхөрч эхэлснийг харав; мөн тэрээр хэлэв: энэ нь залуу болон туяхан мөчрүүдийг гаргаж, мөн үхэхгүй байж болохын тулд би үүнийг тайрч, мөн эргэн тойронд нь сийрүүлж, мөн үүнийг арчилна.
- 5 Мөнхүү улиран тохиох дор тэр өөрийн үгийн дагуу үүнийг тайрч, мөн эргэн тойрныг нь сийрүүлж, мөн арчилсан аж.
- 6 Мөнхүү улиран тохиох дор олон өдрийн дараа энэ нь бага зэрэг цөөн хэдэн, залуу бас туяхан мөчрүүдийг гаргаж эхлэв; гэвч болгоогтун, үүний гол үхэж эхлэв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор талбайн эзэн үүнийг хараад, мөн тэрээр зарцдаа: би энэ модыг алдах ёстой болсон нь намайг гонсойлгож байна; иймийн тул, яваад мөн зэрлэг чидуны модноос мөчрүүдийг нь тайрч мөн тэдгээрийг нааш авчир, мөн бид эдгээр хувхайрч эхэлсэн тэр гол мөчрүүдийг тасдаж авна, мөн бид эдгээр нь шатаагдаж болохын тулд эдгээрийг галд хаях болно.
- 8 Мөн болгоогтун, талбайн Эзэн хэлэв, би эдгээр залуу бөгөөд туяхан мөчрүүдээс олныг нь салган авч мөн эднийг хүссэн газартаа залган суулгах болно; мөн энэ модны үндэс эрсдэх нь хамаагүй, би үр жимсийг нь өөртөө хадгалан үлдээж болно; иймийн тул, би эдгээр залуу мөн туяхан мөчрүүдийг авах болно, мөн би эдгээрийг хүссэн газраа залгах болно.
- 9 Чи зэрлэг чидуны модны мөчрүүдийг ав, мөн тэднийг эдний оронд байранд нь залга; мөн эдгээр нь миний талбайд зай эзлэхгүй байхын тулд би тасдаж авсныгаа галд хаяж мөн шатаах болно.

## Jacob 5

Behold, my brethren, do ye not remember to have read the words of the prophet Zenos, which he spake unto the house of Israel, saying:

Hearken, O ye house of Israel, and hear the words of me, a prophet of the Lord.

For behold, thus saith the Lord, I will liken thee, O house of Israel, like unto a tame olive tree, which a man took and nourished in his vineyard; and it grew, and waxed old, and began to decay.

And it came to pass that the master of the vineyard went forth, and he saw that his olive tree began to decay; and he said: I will prune it, and dig about it, and nourish it, that perhaps it may shoot forth young and tender branches, and it perish not.

And it came to pass that he pruned it, and digged about it, and nourished it according to his word.

And it came to pass that after many days it began to put forth somewhat a little, young and tender branches; but behold, the main top thereof began to perish.

And it came to pass that the master of the vineyard saw it, and he said unto his servant: It grieveth me that I should lose this tree; wherefore, go and pluck the branches from a wild olive tree, and bring them hither unto me; and we will pluck off those main branches which are beginning to wither away, and we will cast them into the fire that they may be burned.

And behold, saith the Lord of the vineyard, I take away many of these young and tender branches, and I will graft them whithersoever I will; and it mattereth not that if it so be that the root of this tree will perish, I may preserve the fruit thereof unto myself; wherefore, I will take these young and tender branches, and I will graft them whithersoever I will.

Take thou the branches of the wild olive tree, and graft them in, in the stead thereof; and these which I have plucked off I will cast into the fire and burn them, that they may not cumber the ground of my vineyard.

10 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэний зарц, талбайн Эзэний үгийн дагуу үйлдэж, мөн зэрлэг чидуны модны мөчрүүдийг залган суулгав.

11 Мөн талбайн Эзэн орчныг нь сийрүүлж, мөн засаж тайраад, мөн арчил хэмээгээд зарцдаа хэлсэн нь: Би энэ модыг алдах нь намайг гонсойлгоно; иймийн тул, эдгээр нь мөхөхгүй байж, би түүний үндсүүдийг хадгалан үлдээж болно хэмээн, би эдгээрийг өөртөө хадгалан үлдээж болох магад хэмээн би энэ зүйлийг хийсэн бөлгөө.

12 Иймийн тул, замаараа одогтун; миний үгсийн дагуу модыг харатгун, мөн үүнийг арчлагтун.

13 Мөн эдгээрийг би талбайнхаа хамгийн алсын хэсэгт хүссэн газраа байрлуулна, хаана гэдэг нь чамд хамаагүй; мөн би модны унаган мөчрүүдийг өөртөө хадгалан үлдээж болохын тулд би үүнийг хийнэ; мөн түүнчлэн, би өөртөө эдгээрийн үр жимсийг ирэх улиралд нөөцөлж болохын тулд хэмээв; учир нь би энэ модыг мөн үүний үр жимсийг алдах болсон нь намайг гонсойлгох бөлгөө.

14 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн замаараа явж, мөн талбайн алсын хэсгүүдэд таримал чидуны модны унаган мөчрүүдийг, өөрийн таалал мөн хүслийн дагуу заримыг нь нэгэнд мөн заримыг нь нөгөөд нууцалсан болой.

15 Мөнхүү улиран тохиох дор урт хугацаа өнгөрөн одож, мөн талбайн Эзэн зарцдаа: Ир, бид талбайд хөдөлмөрлөж болохын тулд, талбай уруу явцгаая хэмээв.

16 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн, мөн түүнчлэн сайхь зарц хөдөлмөрлөхөөр талбай уруу явцгаав. Мөнхүү улиран тохиох дор зарц эзэндээ: Болгоогтун, үүнийг хараач; модыг болгоо хэмээв.

17 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зэрлэг чидуны мөчрүүд залгагдсан мөнөөх модыг үзэж мөн болгоов; мөн энэ нь нахиалан үр жимс өгч эхэлсэн байв. Мөн энэ нь сайн байсныг тэрээр болгоов; мөн жимс нь унаган жимсний адил байсан бөлгөө.

And it came to pass that the servant of the Lord of the vineyard did according to the word of the Lord of the vineyard, and grafted in the branches of the wild olive tree.

And the Lord of the vineyard caused that it should be digged about, and pruned, and nourished, saying unto his servant: It grieveth me that I should lose this tree; wherefore, that perhaps I might preserve the roots thereof that they perish not, that I might preserve them unto myself, I have done this thing.

Wherefore, go thy way; watch the tree, and nourish it, according to my words.

And these will I place in the nethermost part of my vineyard, whithersoever I will, it mattereth not unto thee; and I do it that I may preserve unto myself the natural branches of the tree; and also, that I may lay up fruit thereof against the season, unto myself; for it grieveth me that I should lose this tree and the fruit thereof.

And it came to pass that the Lord of the vineyard went his way, and hid the natural branches of the tame olive tree in the nethermost parts of the vineyard, some in one and some in another, according to his will and pleasure.

And it came to pass that a long time passed away, and the Lord of the vineyard said unto his servant: Come, let us go down into the vineyard, that we may labor in the vineyard.

And it came to pass that the Lord of the vineyard, and also the servant, went down into the vineyard to labor. And it came to pass that the servant said unto his master: Behold, look here; behold the tree.

And it came to pass that the Lord of the vineyard looked and beheld the tree in the which the wild olive branches had been grafted; and it had sprung forth and begun to bear fruit. And he beheld that it was good; and the fruit thereof was like unto the natural fruit.



- 18 Мөн тэрээр зарцдаа хэлэв: Болгоогтун, зэрлэг модны мөчрүүд үндэснээсээ чийг авсан тул үндэс нь их хүч гаргажээ; мөн тэдний үндэс нь их хүчирхэг учир зэрлэг мөчрүүд таримал жимс авчирсан ажээ. Эдүгээ, хэрэв бид эдгээр мөчрүүдийг залгаагүй байсан бол, тэр мод үхэх байсан. Мөн эдүгээ, болгоогтун, би уг модны авчирсан тэр их жимсийг хадгалах болно; мөн түүний жимсийг би өөртөө улирлын тулд нөөцлөх болно хэмээв.
- 19 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцад: Ирэгтүн, талбайн алсын хэсэг тийш явцгаая, мөн би үүний жимсийг дараагийн улиралд өөртөө нөөцөлж болохын тулд уг модны унаган мөчрүүд түүнчлэн их жимс өгсөн эсэхийг үзэцгээе гэв.
- 20 Мөнхүү улиран тохиох дор тэд явж эзэн уг модны унаган мөчрүүдийг нуусан тийш очиж мөн тэрээр зарцдаа: Эдгээрийг болгоогтун гэв; мөн тэр эхлээд анхных нь их үр жимс өгснийг үзэв; мөн түүнчлэн энэ нь сайн байсныг үзэв. Мөн тэрээр зарцад: Үүний жимсийг түү, мөн үүнийг би өөртөө хадгалахын тулд улиралд нь зориулан нөөцөл гэв; учир нь болгоогтун, тэрээр хэлрүүн, энэ удаан хугацаанд би үүнийг арчилсан, мөн энэ нь их үр жимс өглөө гэв.
- 21 Мөнхүү улиран тохиох дор зарц эзэндээ: Та энэ модыг, өөрөөр хэлбэл уг модны энэ мөчрийг тарихаар энд яахан ирсэн билээ? Учир нь болгоогтун, энэ нь таны талбайн бүх газраас хамгийн шимгүй хэсэг нь байсан хэмээв.
- 22 Мөн талбайн Эзэн түүнд, надад битгий зөвлө; энэ нь газрын шимгүй нь байсныг би мэдэж байсан; иймийн тул, би чамд хэлсэн, би үүнийг ийм удаан хугацаанд арчилсан, мөн чи энэ нь их үр жимс өгснийг харж байна шүү дээ хэмээв.
- 23 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа: Нааш харагтун; би түүнчлэн уг модны өөр нэгэн мөчрийг тарьсныг үз; мөн газрын энэ хэсэг нь эхнийхээс илүү шимгүй байсныг чи мэднэ. Гэвч, модыг үзэгтүн. Би үүнийг ийм удаан хугацаанд арчилсан, мөн энэ нь их үр жимс өглөө; тиймийн тул, үүнийг хурааж мөн би үүнийг өөртөө хадгалж болохын тулд улиралд нь нөөцөл хэмээв.

And he said unto the servant: Behold, the branches of the wild tree have taken hold of the moisture of the root thereof, that the root thereof hath brought forth much strength; and because of the much strength of the root thereof the wild branches have brought forth tame fruit. Now, if we had not grafted in these branches, the tree thereof would have perished. And now, behold, I shall lay up much fruit, which the tree thereof hath brought forth; and the fruit thereof I shall lay up against the season, unto mine own self.

And it came to pass that the Lord of the vineyard said unto the servant: Come, let us go to the nethermost part of the vineyard, and behold if the natural branches of the tree have not brought forth much fruit also, that I may lay up of the fruit thereof against the season, unto mine own self.

And it came to pass that they went forth whither the master had hid the natural branches of the tree, and he said unto the servant: Behold these; and he beheld the first that it had brought forth much fruit; and he beheld also that it was good. And he said unto the servant: Take of the fruit thereof, and lay it up against the season, that I may preserve it unto mine own self; for behold, said he, this long time have I nourished it, and it hath brought forth much fruit.

And it came to pass that the servant said unto his master: How comest thou hither to plant this tree, or this branch of the tree? For behold, it was the poorest spot in all the land of thy vineyard.

And the Lord of the vineyard said unto him: Counsel me not; I knew that it was a poor spot of ground; wherefore, I said unto thee, I have nourished it this long time, and thou beholdest that it hath brought forth much fruit.

And it came to pass that the Lord of the vineyard said unto his servant: Look hither; behold I have planted another branch of the tree also; and thou knowest that this spot of ground was poorer than the first. But, behold the tree. I have nourished it this long time, and it hath brought forth much fruit; therefore, gather it, and lay it up against the season, that I may preserve it unto mine own self.

24 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа дахин хэлэв: Нааш харагтун, мөн түүнчлэн миний тарьсан, өөр нэгэн мөчрийг үзэгтүн; би үүнийг түүнчлэн арчилсныг, мөн энэ нь үр жимс гаргасныг үзэгтүн.

25 Мөн тэрээр зарцад: Нааш харагтун мөн эцсийнхийг нь үзэгтүн. Болгоогтун, үүнийг би газрын сайн хэсэгт тарьсан; мөн би үүнийг энэ урт хугацаанд арчилсан, мөн уг модны зөвхөн хэсэг нь л таримал жимс өгч мөн уг модны бусад хэсэг нь зэрлэг жимс өгчээ; болгоогтун, би энэ модыг бусдын адил арчилсан хэмээв.

26 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцад: сайн жимс өгөөгүй мөчрүүдийг тайрагтун, мөн тэднийг галд хаягтун хэмээв.

27 Гэвч болгоогтун, зарц түүнд хэлэв: Энэ нь танд сайн үр жимс өгч, та үүнийг улиралд нь зориулан нөөцөлж магадгүй учир үүнийг тайрч, мөн орчныг нь сийрүүлж, мөн үүнийг бага зэрэг дахин арчилцгаая.

28 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн, мөн талбайн Эзэний зарц талбайн бүх жимсийг арчилсан бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор урт хугацаа улиран одов, мөн талбайн Эзэн зарцдаа: Ирэгтүн, бид талбайд дахин хөдөлмөрлөж болохын тулд талбай уруу очицгооё. Учир нь болгоогтун, цаг нь ойртож, мөн төгсгөл удахгүй ирнэ, иймийн тул, би өөртөө зориулж улирлынх нь тулд жимс нөөцлөх ёстой хэмээв.

30 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн мөн зарц талбайд уруудан ирэв; мөн тэд унаган мөчрүүд нь хугалагдсан мөн зэрлэг мөчрүүд залгагдсан тэрхүү модонд ирэв; мөн болгоогтун, бүх төрлийн жимс уг модыг бөхийлгөсөн байв.

31 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн жимснээс амсаж үзэв, төрөл бүрийнх нь тоогоор болой. Мөн талбайн Эзэн хэлэв: Болгоогтун, энэ урт хугацаанд энэ модыг бид арчилсан, мөн би өөртөө улиралд нь зориулан их жимс нөөцөлсөн болой хэмээв.

And it came to pass that the Lord of the vineyard said again unto his servant: Look hither, and behold another branch also, which I have planted; behold that I have nourished it also, and it hath brought forth fruit.

And he said unto the servant: Look hither and behold the last. Behold, this have I planted in a good spot of ground; and I have nourished it this long time, and only a part of the tree hath brought forth tame fruit, and the other part of the tree hath brought forth wild fruit; behold, I have nourished this tree like unto the others.

And it came to pass that the Lord of the vineyard said unto the servant: Pluck off the branches that have not brought forth good fruit, and cast them into the fire.

But behold, the servant said unto him: Let us prune it, and dig about it, and nourish it a little longer, that perhaps it may bring forth good fruit unto thee, that thou canst lay it up against the season.

And it came to pass that the Lord of the vineyard and the servant of the Lord of the vineyard did nourish all the fruit of the vineyard.

And it came to pass that a long time had passed away, and the Lord of the vineyard said unto his servant: Come, let us go down into the vineyard, that we may labor again in the vineyard. For behold, the time draweth near, and the end soon cometh; wherefore, I must lay up fruit against the season, unto mine own self.

And it came to pass that the Lord of the vineyard and the servant went down into the vineyard; and they came to the tree whose natural branches had been broken off, and the wild branches had been grafted in; and behold all sorts of fruit did cumber the tree.

And it came to pass that the Lord of the vineyard did taste of the fruit, every sort according to its number. And the Lord of the vineyard said: Behold, this long time have we nourished this tree, and I have laid up unto myself against the season much fruit.

32 Гэвч болгоогтун, энэ удаа энэ нь их жимс өгсөн байв, мөн тэнд нэгээхэн ч сайн нь үгүй бөлгөө. Мөн болгоогтун, муу жимсний бүх төрлүүд байв; бидний бүх хөдөлмөрөөс үл хамааран, мөн надад ямар ч ашигийг үл өгөв, мөн эдүгээ би энэ модыг алдах нь намайг гонсойлгож байна.

33 Мөн талбайн Эзэн зарцад: Би дахин үүний сайн үр жимсийг өөртөө авч болохын тулд, бид уг модонд юу хийх билээ? хэмээв.

34 Мөн зарц Эзэндээ: Болгоогтун, эдгээрийн үндсүүдийг арчлахын тулд та чидуны зэрлэг модны мөчрүүдийг залгасан учир, эдгээр нь амьд мөн эдгээр нь эрсдээгүй байна; иймийн тул эдгээр нь одоохондоо сайн хэвээр байгааг та болгоож байна хэмээв.

35 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа: Энэ мод надад ямар ч ашиггүй, мөн энэ нь олиггүй муу жимс өгөх аваас мөн түүний үндэс ч надад ашиггүй хэмээв.

36 Гэсэн хэдий ч, үндсүүд нь сайн гэдгийг би мэднэ, мөн өөрийнхөө зорилгын тулд би эдгээрийг хадгалсан бөлгөө; мөн эдний их хүчний учир тэдгээр нь өмнө нь зэрлэг мөчрүүдээс сайн үр жимс өгсөн бөлгөө.

37 Гэвч болгоогтун, зэрлэг мөчрүүд ургаж мөн түүний үндэснүүдийн хэрээс хэтэрчээ; мөн зэрлэг мөчрүүд үндсээ давж гарсан учир энэ нь олиггүй муу жимс ихээр өгчээ; мөн энэ нь маш ихээр муу үр жимс авчирсны учир энэ нь үхэж эхэлснийг та болгоож буй; мөн бид үүнийг хадгалахаар үүний төлөө ямар нэгэн зүйл хийхгүй бол, энэ нь удахгүй боловсрон галд хаягдаж магадгүй болжээ.

38 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцдаа: Талбайн хамгийн алсын хэсгүүдэд уруудан очигчоо, мөн унаган мөчрүүд түүнчлэн олиггүй муу үр жимс өгсөн эсэхийг үзье хэмээв.

39 Мөнхүү улиран тохиох дор тэд талбайн хамгийн алсын хэсгүүдэд уруудан очигчоов. Мөнхүү улиран тохиох дор унаган мөчрүүд ч гэсэн түүнчлэн өмхөрсөн байхыг тэд харав; тийм ээ, эхнийх мөн дараагийнх мөн түүнчлэн эцсийнх нь; мөн тэдгээр нь бүгд өмх болсон байв.

But behold, this time it hath brought forth much fruit, and there is none of it which is good. And behold, there are all kinds of bad fruit; and it profiteth me nothing, notwithstanding all our labor; and now it grieveth me that I should lose this tree.

And the Lord of the vineyard said unto the servant: What shall we do unto the tree, that I may preserve again good fruit thereof unto mine own self?

And the servant said unto his master: Behold, because thou didst graft in the branches of the wild olive tree they have nourished the roots, that they are alive and they have not perished; wherefore thou beholdest that they are yet good.

And it came to pass that the Lord of the vineyard said unto his servant: The tree profiteth me nothing, and the roots thereof profit me nothing so long as it shall bring forth evil fruit.

Nevertheless, I know that the roots are good, and for mine own purpose I have preserved them; and because of their much strength they have hitherto brought forth, from the wild branches, good fruit.

But behold, the wild branches have grown and have overrun the roots thereof; and because that the wild branches have overcome the roots thereof it hath brought forth much evil fruit; and because that it hath brought forth so much evil fruit thou beholdest that it beginneth to perish; and it will soon become ripened, that it may be cast into the fire, except we should do something for it to preserve it.

And it came to pass that the Lord of the vineyard said unto his servant: Let us go down into the nethermost parts of the vineyard, and behold if the natural branches have also brought forth evil fruit.

And it came to pass that they went down into the nethermost parts of the vineyard. And it came to pass that they beheld that the fruit of the natural branches had become corrupt also; yea, the first and the second and also the last; and they had all become corrupt.

40 Мөн эцсийнх нь зэрлэг жимс нь модны сайн үр авчирсан тэр хэсгийг, бүр уг мөчрийг өгөрч мөн үхмэл болтол нь давамгайлсан байлаа.

41 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн уйлж, мөн зарцдаа: Талбайнхаа төлөө би өөр юу хийж чадах сан билээ? гэв.

42 Болгоогтун, талбайн эдгээрээс бусад бүх үр жимс, өмхөрч муудсаныг би мэдэв. Мөн эдүгээ сайн үр жимс нэгэнтээ өгсөн тэдгээр нь түүнчлэн өмхөрч муудсан ажээ; мөн эдүгээ миний талбайн бүх мод тас цавчаад галд хаяхаас өөрөөр юунд ч хэрэггүй болжээ.

43 Мөн би газрын сайн хэсэгт тарьсан ч мөчир нь өмхөрч муудсан энэ эцсийнхийг тийм ээ, бүр миний талбайн газрын бусад бүх хэсгээс дээгүүрт сонгогдсон үүнийг үзэгтүн.

44 Мөн би энэ модыг оронд нь тарьж болохын тулд газрын энэ хэсэгт байсан саад болох зүйлийг би түүнчлэн тайрч хаясныг чи харсан шүү дээ.

45 Мөн үүний нэг хэсэг нь сайн үр жимс өгч мөн нөгөө хэсэг нь зэрлэг үр жимс өгснийг чи харсан; мөн би үүний мөчрүүдийг тасдан авч мөн галд хаяагүйн учир, болгоогтун, тэд гээр нь сайн мөчрийг даван гарсан учир энэ нь хатсан ажгуу.

46 Мөн эдүгээ, болгоогтун, бидний талбайд минь зориулсан тэр бүх арчилгаанаас үл хамааран үүний модод өмхөрсөн учир тэд сайн үр жимс өгөхгүй болжээ; мөн би эдгээрийг хадгалж, өөртөө зориулан улиралд нь үр жимсийг нь нөөцөлж болно гэж найдсан бөлгөө. Гэвч, болгоогтун, эдгээр нь зэрлэг чидуны модтой адил болж мөн эдгээрийг тас цавчаад мөн галд хаяхаас өөрөөр тусгүй болжээ; мөн би эдгээрнийг алдах болсон нь намайг гонсойлгож байна.

47 Гэвч талбайдаа би өөр юу хийж чадах байсан билээ? Би үүнийг арчлахгүйн тулд гараа амраасан гэж үү? Үгүй, би үүнийг арчилсан, мөн орчныг нь сийрүүлсэн, мөн би үүнийг тайрсан, бас би үүнийг бордсон; мөн бараг л бүх өдрийн турш би гараа сунгаж байсан, мөн төгсгөл ойртож байна. Тэгээд талбайнхаа бүх моддыг тас цавчиж, мөн эдгээрийг шатаагдахын тулд галд хаях нь, энэ нь намайг гонсойлгож байна. Миний талбайг хэрэгцээгүй болгох тэр нь хэн билээ

And the wild fruit of the last had overcome that part of the tree which brought forth good fruit, even that the branch had withered away and died.

And it came to pass that the Lord of the vineyard wept, and said unto the servant: What could I have done more for my vineyard?

Behold, I knew that all the fruit of the vineyard, save it were these, had become corrupted. And now these which have once brought forth good fruit have also become corrupted; and now all the trees of my vineyard are good for nothing save it be to be hewn down and cast into the fire.

And behold this last, whose branch hath withered away, I did plant in a good spot of ground; yea, even that which was choice unto me above all other parts of the land of my vineyard.

And thou beheldest that I also cut down that which cumbered this spot of ground, that I might plant this tree in the stead thereof.

And thou beheldest that a part thereof brought forth good fruit, and a part thereof brought forth wild fruit; and because I plucked not the branches thereof and cast them into the fire, behold, they have overcome the good branch that it hath withered away.

And now, behold, notwithstanding all the care which we have taken of my vineyard, the trees thereof have become corrupted, that they bring forth no good fruit; and these I had hoped to preserve, to have laid up fruit thereof against the season, unto mine own self. But, behold, they have become like unto the wild olive tree, and they are of no worth but to be hewn down and cast into the fire; and it grieveth me that I should lose them.

But what could I have done more in my vineyard? Have I slackened mine hand, that I have not nourished it? Nay, I have nourished it, and I have digged about it, and I have pruned it, and I have dunged it; and I have stretched forth mine hand almost all the day long, and the end draweth nigh. And it grieveth me that I should hew down all the trees of my vineyard, and cast them into the fire that they should be burned. Who is it that has corrupted my vineyard?

48 Мөнхүү улиран тохиох дор зарц эзэндээ: Энэ нь таны талбайн сүрлэгээс бус уу—үүний мөчрүүд тэр сайн үндсүүдээ давсан бус уу? Мөн мөчрүүд нь үндсүүдээ давамгайлсны учир болгоогтун, тэд гээр нь үндэснүүдээс илүүтэй хурдан ургаж, өөрсдөдөө хүч чадлыг авчээ гэв. Болгоогтун, би хэлнэ, энэ нь таны талбайн модод өмхөрч байгаагийн шалтгаан уу

49 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцад хэлэв: Явж мөн талбайн модыг тас цавчицгаая, мөн тэдгээр нь талбайн минь хөрсийг хэрэгцээгүй болгохгүйн тулд тэдгээрийг галд хаяцгаая, учир нь би бүгдийг хийсэн шүү дээ. Би талбайнхаа төлөө өөр юу хийж чадах байсан билээ

50 Гэвч, болгоогтун, зарц талбайн Эзэнд: Үүнийг дахин бага зэрэг түдгэлзээч хэмээв.

51 Мөн Эзэн хэлэв: Тийм ээ, би дахин бага зэрэг хүлээе, учир нь талбайнхаа моддыг алдах нь намайг гонсойлгож байна.

52 Иймийн тул, талбайнхаа хамгийн алслагдсан хэсгүүдэд миний тарьсан эдгээрийн мөчрүүдээс авцгаая, мөн эдгээрийг авчирсан тэр модондоо залгацгаая; мөн жимс нь хамгийн гашуун мөчрүүдийг модноос нь тайрч авъя, мөн тэдгээрийн оронд модны унаган мөчрүүдийг залгая.

53 Мөн үүнийг би уг модыг эрсдүүлэхгүй байж болохын тул хийх болно, магадгүй, би үүний үндсүүдийг өөрийнхөө зорилгын тулд өөртөө хадгалж болохын тулд буюу.

54 Мөн, болгоогтун, хүссэн газартаа тарьсан тэр модны унаган мөчрүүдийн үндсүүд одоохондоо амьд байгаа; иймийн тул, тэдгээрийг би түүнчлэн миний өөрийнхөө зорилгын төлөө хадгалж болохын тулд, би энэ модны мөчрүүдийг тайрч мөн эднийг тэдгээрт залгах болно. Тийм ээ, тэдгээр нь хангалттай хүчтэй болохоороо надад сайн жимс өгч магадгүйн тул, мөн би талбайнхаа үр жимсэнд сүр жавхлантай байхын тулд, би түүнчлэн өөртөө уг үндсүүдийг ч хадгалж болохын тулд би тэдгээрт өөрсдийнх нь эх модны мөчрүүдийг залгах болно.

55 Мөнхүү улиран тохиох дор зэрлэг болсон унаган модноос тэд авч мөн түүнчлэн зэрлэг болсон унаган моднуудад залгав.

And it came to pass that the servant said unto his master: Is it not the loftiness of thy vineyard—have not the branches thereof overcome the roots which are good? And because the branches have overcome the roots thereof, behold they grew faster than the strength of the roots, taking strength unto themselves. Behold, I say, is not this the cause that the trees of thy vineyard have become corrupted?

And it came to pass that the Lord of the vineyard said unto the servant: Let us go to and hew down the trees of the vineyard and cast them into the fire, that they shall not cumber the ground of my vineyard, for I have done all. What could I have done more for my vineyard?

But, behold, the servant said unto the Lord of the vineyard: Spare it a little longer.

And the Lord said: Yea, I will spare it a little longer, for it grieveth me that I should lose the trees of my vineyard.

Wherefore, let us take of the branches of these which I have planted in the nethermost parts of my vineyard, and let us graft them into the tree from whence they came; and let us pluck from the tree those branches whose fruit is most bitter, and graft in the natural branches of the tree in the stead thereof.

And this will I do that the tree may not perish, that, perhaps, I may preserve unto myself the roots thereof for mine own purpose.

And, behold, the roots of the natural branches of the tree which I planted whithersoever I would are yet alive; wherefore, that I may preserve them also for mine own purpose, I will take of the branches of this tree, and I will graft them in unto them. Yea, I will graft in unto them the branches of their mother tree, that I may preserve the roots also unto mine own self, that when they shall be sufficiently strong perhaps they may bring forth good fruit unto me, and I may yet have glory in the fruit of my vineyard.

And it came to pass that they took from the natural tree which had become wild, and grafted in unto the natural trees, which also had become wild.

- 56 Мөн тэд түүнчлэн зэрлэг болсон унаган моддоос авч мөн тэдгээрийн эх модонд нь залгасан ажээ.
- 57 Мөн талбайн Эзэн зарцдаа: Уг модноос тэдгээр нь хамгийн гашуун биш аваас зэрлэг мөчрүүдийг бүү тайр; мөн миний хэлсний дагуу чи тэдгээрт залгах болно хэмээв.
- 58 Мөн бид талбайн моддыг дахин арчлах болно, мөн бид үүний мөчрүүдийг тайрах болно; мөн үхэх ёстой, өгөрсөн мөчрүүдийг уг моднуудаас бид таслан авч, мөн тэдгээрийг галд хаях болно.
- 59 Мөн түүний үндсүүд сайныхаа учир хүчийг авч магадгүйн учир би үүнийг хийх болно; мөн мөчрүүдийг сольсны учир сайн нь муугаа давамгайлж магадгүйн тулд буюу.
- 60 Мөн би унаган мөчрүүд мөн тэдгээрийн үндсүүдийг хадгалсан учир, мөн би унаган мөчрүүдийг тэдний эх модонд дахин залгасан учир, мөн талбайнхаа уг модод дахин сайн үр жимс авчирч магад хэмээх тул эх модных нь үндсүүдийг хадгалж үлдээв; мөн би талбайнхаа үр жимсэнд дахин баясаж болохын тулд би анхны үр жимсний үндсүүдийг мөн мөчрүүдийг хадгалсандаа үлэмж баясаж болохын тулд буюу—
- 61 Иймийн тул, би унаган үр жимсийг, сайн мөн бусад бүх жимснээс хамгийн эрхэм унаган үр жимсийг авчирч болох замыг бэлтгэж болно хэмээн бид талбайд өөрсдийн хүчээр шаргуу хөдөлмөрлөж болохын тулд очиж зарц нарыг дуудагтун.
- 62 Иймийн тул, энэхүү эцсийн удаа бид очиж мөн чадлаараа хөдөлмөрлөцгөөе, учир нь болгоогтун, төгсгөл ойртож буй, мөн энэ нь би талбайгаа засаж тайрах эцсийн удаа болой.
- 63 Мөчрүүдийг залгагтун; тэд эхнийх байж, мөн эхнийх нь эцсийнх байж болохын тулд эцсийнх дээр нь эхлэгтүн, мөн моддын эргэн тойрныг хөгшин болон залуу, эхний болон эцсийнх аль алиныг нь сийрэгжүүл; мөн эцсийнх болон эхнийх нь дахин нэгэнтээ эцсийн удаа арчлагдаж болохын тулд буюу.

And they also took of the natural trees which had become wild, and grafted into their mother tree.

And the Lord of the vineyard said unto the servant: Pluck not the wild branches from the trees, save it be those which are most bitter; and in them ye shall graft according to that which I have said.

And we will nourish again the trees of the vineyard, and we will trim up the branches thereof; and we will pluck from the trees those branches which are ripened, that must perish, and cast them into the fire.

And this I do that, perhaps, the roots thereof may take strength because of their goodness; and because of the change of the branches, that the good may overcome the evil.

And because that I have preserved the natural branches and the roots thereof, and that I have grafted in the natural branches again into their mother tree, and have preserved the roots of their mother tree, that, perhaps, the trees of my vineyard may bring forth again good fruit; and that I may have joy again in the fruit of my vineyard, and, perhaps, that I may rejoice exceedingly that I have preserved the roots and the branches of the first fruit—

Wherefore, go to, and call servants, that we may labor diligently with our might in the vineyard, that we may prepare the way, that I may bring forth again the natural fruit, which natural fruit is good and the most precious above all other fruit.

Wherefore, let us go to and labor with our might this last time, for behold the end draweth nigh, and this is for the last time that I shall prune my vineyard.

Graft in the branches; begin at the last that they may be first, and that the first may be last, and dig about the trees, both old and young, the first and the last; and the last and the first, that all may be nourished once again for the last time.

64 Иймийн тул, тэдгээрийн орчныг сийрүүл, мөн тэдгээрийг тайрч зас, мөн тэдгээрийг дахин нэгэнтээ эцсийн удаа борд, учир нь төгсгөл ойртож буй. Мөн хэрэв эдгээр эцсийн залгалтууд ургаж мөн унаган үр жимс өгөх аваас, тэдгээр нь ургаж болохын тулд та нар тэдгээрт замыг бэлтгэх болно.

65 Мөн тэдгээр нь ургаж эхлэхээр сайны хүч мөн үүний хэмжээний дагуу та нар гашуун үр жимс өгөх мөчрүүдийг цэвэрлэн зайлуулах болно; мөн үүний үндсүүд залгагдсандаа дэндүү хүчирхэг болж, мөн тэдгээрийг мөхөөж, мөн би талбайнхаа моддыг алдах болуузай хэмээн та нар үүний мууг бүгдийг нэгмөсөн цэвэрлэн зайлуулахгүй.

66 Учир нь талбайнхаа моддыг алдах нь намайг гонсойлгож байна; иймийн тул, үндэс болон дээд хэсэг нь адил хүчтэй байхын тулд та нар сайныг ургуулахын хамтаар сайн нь муугаа давамгайлж мөн тэд талбайн минь хөрсийг хэрэгцээгүй болгохгүйн тул муу нь тас цавчигдан мөн галд хаягдах болтол буюу мууг зайлуулан цэвэрлэх болно; мөн тийн би мууг талбайгаасаа гарган шүүрдэж зайлуулах болно.

67 Мөн би унаган модны мөчрүүдийг дахин унаган модонд нь залгах болно;

68 Мөн унаган модны мөчрүүдийг би дахин модны унаган мөчрүүдэд нь залгах болно; мөн тийн тэд унаган үр жимс өгөхийн тулд би тэдгээрийг дахин хамтатгаж, мөн тэдгээр нь нэг байх болно.

69 Мөн муу нь, тийм ээ, бүр миний талбайн бүх нутаг дэвсгэрээс зайлуулагдах болно; учир нь болгоогтун, зөвхөн энэ нэг л удаа би талбайгаа тайрч засах болно.

70 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн зарцаа илгээв; мөн зарц явж мөн Эзэн түүнд зарлигласанчлангаар үйлдэв, мөн бусад зарц нарыг авчрав; мөн тэд цөөн байлаа.

71 Мөн талбайн Эзэн тэдэнд: Яв, мөн өөрсдийн хүчээр талбайд хөдөлмөрлө. Учир нь болгоогтун, энэ бол би талбайгаа эцсийн удаа арчлах болно; учир нь төгсгөл ойрхон байна, мөн улирал нь хурдан ирэх бөлгөө; мөн хэрэв та нар өөрсдийн хүчээр надтай хамт хөдөлмөрлөх бөгөөс удахгүй ирэх тэр цагт зориулж би өөртөө нөөцлөх жимсэнд та нар баясах болно гэв.

Wherefore, dig about them, and prune them, and dung them once more, for the last time, for the end draweth nigh. And if it be so that these last grafts shall grow, and bring forth the natural fruit, then shall ye prepare the way for them, that they may grow.

And as they begin to grow ye shall clear away the branches which bring forth bitter fruit, according to the strength of the good and the size thereof; and ye shall not clear away the bad thereof all at once, lest the roots thereof should be too strong for the graft, and the graft thereof shall perish, and I lose the trees of my vineyard.

For it grieveth me that I should lose the trees of my vineyard; wherefore ye shall clear away the bad according as the good shall grow, that the root and the top may be equal in strength, until the good shall overcome the bad, and the bad be hewn down and cast into the fire, that they cumber not the ground of my vineyard; and thus will I sweep away the bad out of my vineyard.

And the branches of the natural tree will I graft in again into the natural tree;

And the branches of the natural tree will I graft into the natural branches of the tree; and thus will I bring them together again, that they shall bring forth the natural fruit, and they shall be one.

And the bad shall be cast away, yea, even out of all the land of my vineyard; for behold, only this once will I prune my vineyard.

And it came to pass that the Lord of the vineyard sent his servant; and the servant went and did as the Lord had commanded him, and brought other servants; and they were few.

And the Lord of the vineyard said unto them: Go to, and labor in the vineyard, with your might. For behold, this is the last time that I shall nourish my vineyard; for the end is nigh at hand, and the season speedily cometh; and if ye labor with your might with me ye shall have joy in the fruit which I shall lay up unto myself against the time which will soon come.

72 Мөнхүү улиран тохиох дор зарц нар явж мөн хүч чадлаараа хөдөлмөрлөв; мөн талбайн Эзэн тэдэнтэй түүнчлэн хөдөлмөрлөжээ; мөн тэд талбайн Эзэний зарлигуудыг бүх зүйлд дуулгавартай дагасан болой.

73 Мөн талбайд дахин унаган жимс нь бий болж эхлэв; мөн унаган мөчрүүд нь ургаж бас үлэмж өтгөрч эхлэв; мөн зэрлэг мөчрүүд тайрагдаж басхүү зайлуулагдаж эхлэв; мөн тэд үндэс болон үүний дээд хэсгийг хүчнийх нь дагуу адил тэгш байлгасан бөлгөө.

74 Мөн тэд ийн бүхий л идэвхээрээ, талбайн Эзэний зарлигуудын дагуу, бүр муу нь талбайгаас зайлуулагдтал хөдөлмөрлөв, мөн Эзэн моддын дахин өгч эхэлсэн унаган жимсийг өөртөө хадгалсан болой; мөн тэдгээр нь нэгэн биеийн адил болов; мөн үр жимс нь адил тэгш болов; мөн талбайн Эзэн түүнд эхлэлээс аваад хамгаас үлэмж эрхэм байсан унаган жимсийг өөртөө хадгалсан бөлгөө.

75 Мөнхүү улиран тохиох дор талбайн Эзэн өөрийнх нь жимс сайн байсныг харж мөн түүний талбай дахин муудаагүй байгааг харж тэрээр зарц нараа дуудаж мөн тэдэнд хэлэв: Болгоогтун, учир нь энэ эцсийн удаа бид талбайг минь арчилсан билээ; мөн би тааллынхаа дагуу үйлдсэнийг та нар харлаа; мөн би бүр унаган жимсийг хадгалсан тул тэр нь сайн байна, бүр эхлэлд байсны адил бөлгөө. Мөн та нар адислагдсан болой; учир нь та нар надтай хамт миний талбайд шаргуугаар хөдөлмөрлөж байлаа, мөн миний зарлигуудыг дагасан, мөн талбай минь дахин муудаагүйн учир, надад унаган жимсийг дахин авчирлаа, мөн муу нь зайлуулагдсан, болгоогтун та нар надтай хамт талбайн минь үр жимсний учир баясах болно.

76 Учир нь болгоогтун, хурдан ирэх тэр улиралд зориулж би өөртөө талбайнхаа жимсийг удаан хугацаанд нөөцлөх болно; мөн би талбайгаа эцсийн удаа арчилсан мөн үүнийг тайрч зассан, мөн орчныг нь сийрэгжүүлсэн, мөн үүнийг бордсон билээ; иймийн тул, би ярьсныхаа дагуу, удаан хугацаагаар уг жимснээс өөртөө нөөцлөх болно.

And it came to pass that the servants did go and labor with their might; and the Lord of the vineyard labored also with them; and they did obey the commandments of the Lord of the vineyard in all things.

And there began to be the natural fruit again in the vineyard; and the natural branches began to grow and thrive exceedingly; and the wild branches began to be plucked off and to be cast away; and they did keep the root and the top thereof equal, according to the strength thereof.

And thus they labored, with all diligence, according to the commandments of the Lord of the vineyard, even until the bad had been cast away out of the vineyard, and the Lord had preserved unto himself that the trees had become again the natural fruit; and they became like unto one body; and the fruits were equal; and the Lord of the vineyard had preserved unto himself the natural fruit, which was most precious unto him from the beginning.

And it came to pass that when the Lord of the vineyard saw that his fruit was good, and that his vineyard was no more corrupt, he called up his servants, and said unto them: Behold, for this last time have we nourished my vineyard; and thou beholdest that I have done according to my will; and I have preserved the natural fruit, that it is good, even like as it was in the beginning. And blessed art thou; for because ye have been diligent in laboring with me in my vineyard, and have kept my commandments, and have brought unto me again the natural fruit, that my vineyard is no more corrupted, and the bad is cast away, behold ye shall have joy with me because of the fruit of my vineyard.

For behold, for a long time will I lay up of the fruit of my vineyard unto mine own self against the season, which speedily cometh; and for the last time have I nourished my vineyard, and pruned it, and dug about it, and dunged it; wherefore I will lay up unto mine own self of the fruit, for a long time, according to that which I have spoken.



77 Мөн олиггүй жимс талбайд минь дахин ирэх цаг болоход би сайныг бас мууг нь цуглуулах болно; мөн сайныг нь би өөртөө хадгалах болно, мөн мууг нь би үүнийг өөрийнх нь байранд нь зайлуулах болно. Мөн тэгээд улирал бас төгсгөл ирнэ; мөн талбайгаа би галд шатаагдахаар болгоно.

And when the time cometh that evil fruit shall again come into my vineyard, then will I cause the good and the bad to be gathered; and the good will I preserve unto myself, and the bad will I cast away into its own place. And then cometh the season and the end; and my vineyard will I cause to be burned with fire.

## Иаков 6

- 1 Мөн эдүгээ, болгоогтун, ах дүү нар минь, би та нарт бошиглоно хэмээн хэлсэнчлэн, болгоогтун, энэ бол миний бошиглол—тэрбээр тэднийг таримал чидуны модтой адилтгасан, Израилын угсааны талаарх, бошиглогч Зиносын ярьсан зүйлүүд нь, гарцаагүй улиран тохиох ёстой.
- 2 Мөн тэрбээр хүмүүсээ хоёр дахь удаагаа нэгтгэхээр мутраа дахин хөдөлгөх тэр өдөр, тийм ээ, бүр эцсийн удаа, Их Эзэний үйлчлэгчид түүний хүчээр талбайг нь арчилж мөн тайрч засахаар урагш одох тэр өдөр; мөн үүний дараа төгсгөл удахгүй ирнэ.
- 3 Мөн түүний талбайд шаргуугаар хөдөлмөрлөсөн тэд хичнээн ихээр адислагдсан билээ; мөн өөрсдийн байранд зайлуулагдах тэд хичнээн ихээр зүхэгдсэн билээ! Мөн дэлхий галаар шатаагдах болно.
- 4 Мөн Бурхан минь бидэнд хичнээн нигүүлсэнгүй билээ, учир нь тэрбээр Израилын угсааны үндсүүдийг мөн мөчрүүдийг аль алиныг нь санадаг бөлгөө; мөн тэрбээр бүхэл өдрийн турш тэдэнд мутраа урагш сунгадаг; мөн тэд зөрүүд бас эсэргүүцэгч хүмүүс; гэвч зүрхээ хатууруулахгүй тэд Бурханы хаант улсад аврагдах болно.
- 5 Иймийн тул, хайрт ах дүү нар минь, та нарыг чанд үгсээр наманчлаасай хэмээн, мөн зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор ирж, мөн тэрбээр та нарт үнэнчийн адил Бурханд үнэнч байхыг би гуйна. Мөн түүний нигүүлслийн мутар та нарын зүг өдрийн гэрэлд сунгагдсан байхад, зүрх сэтгэлээ бүү хатууруулаач.
- 6 Тийм ээ, өнөөдөр, хэрэв та нар түүний дууг сонсёе гэвэл зүрх сэтгэлээ бүү хатууруулаач; учир нь та нар яагаад үхэх ёстой билээ
- 7 Учир нь болгоогтун, та нар Бурханы сайн үгээр бүхэл өдрийн турш арчлагдсаны дараа, та нар тас цавчигдан мөн галд хаягдах ёстойн улмаас та нар олиггүй үр жим гарган авчрах бус уу

## Jacob 6

And now, behold, my brethren, as I said unto you that I would prophesy, behold, this is my prophecy—that the things which this prophet Zenos spake, concerning the house of Israel, in the which he likened them unto a tame olive tree, must surely come to pass.

And the day that he shall set his hand again the second time to recover his people, is the day, yea, even the last time, that the servants of the Lord shall go forth in his power, to nourish and prune his vineyard; and after that the end soon cometh.

And how blessed are they who have labored diligently in his vineyard; and how cursed are they who shall be cast out into their own place! And the world shall be burned with fire.

And how merciful is our God unto us, for he remembereth the house of Israel, both roots and branches; and he stretches forth his hands unto them all the day long; and they are a stiffnecked and a gainsaying people; but as many as will not harden their hearts shall be saved in the kingdom of God.

Wherefore, my beloved brethren, I beseech of you in words of soberness that ye would repent, and come with full purpose of heart, and cleave unto God as he cleaveth unto you. And while his arm of mercy is extended towards you in the light of the day, harden not your hearts.

Yea, today, if ye will hear his voice, harden not your hearts; for why will ye die?

For behold, after ye have been nourished by the good word of God all the day long, will ye bring forth evil fruit, that ye must be hewn down and cast into the fire?

- 8 Болгоогтун, та нар эдгээр үгсийг хүлээн авахгүй гэж үү? Та нар бошиглогчдын үгсийг эсэргүүцдэг; мөн түүний талаар ийм олон нь ярьсны дараа, Христийн талаар яригдсан үгсийг бүгдийг та нар эсэргүүцэх гэж үү; мөн Христийн сайн үгийг, мөн Бурханы хүчийг, мөн Ариун Сүнсний бэлгийг үгүйсгэж, мөн Ариун Сүнсийг зайлуулан, мөн та нарын төлөө үүсгэгдсэн, гэтэлгэлийн агуу төлөвлөгөөгөөр элэг доог хийх гэж үү
- 9 Та нар хэрэв эдгээр зүйлийг үйлдвээс, Христ дэх гэтэлгэлийн мөн амилуулалтын хүч, та нарыг Бурханы тавцангийн өмнө аймшигт гэмтэйгээр болон ичгүүртэйгээр зогсоохоор авчрах болно гэдгийг та нар эс мэдэх гэж үү
- 10 Мөн шударга ёсны хүчний дагуу, учир нь шударга ёс үгүйсгэгдэж чадахгүй, та нар галт ба хүхэрт нууранд очих ёстой, дөл нь унтраагдашгүй тэр, мөн утаа нь үеийн үед бас үүрд уугих тэр, галт болон хүхэрт нуур нь төгсгөлгүй зовлон бөлгөө.
- 11 Ай тэгээд, хайрт ах дүү нар минь, наманчлагтун та нар, мөн давчуу хаалгаар орогтун, мөн нарийн замаар, мөнх амьдралыг олох хүртлээ үргэлжлүүлэн явагтун.
- 12 Ай мэргэн байгтун; би өөр юу хэлж чадахсан билээ
- 13 Эцэст нь, Бурханы таалалт тавцан, ёс бус тэдний аймаар айдас мөн аюумшгаар цохих тэрхүү тавцангийн өмнө би та нартай уулзах хүртэл, та нарт сайныг хүсье. Амен.

Behold, will ye reject these words? Will ye reject the words of the prophets; and will ye reject all the words which have been spoken concerning Christ, after so many have spoken concerning him; and deny the good word of Christ, and the power of God, and the gift of the Holy Ghost, and quench the Holy Spirit, and make a mock of the great plan of redemption, which hath been laid for you?

Know ye not that if ye will do these things, that the power of the redemption and the resurrection, which is in Christ, will bring you to stand with shame and awful guilt before the bar of God?

And according to the power of justice, for justice cannot be denied, ye must go away into that lake of fire and brimstone, whose flames are unquenchable, and whose smoke ascendeth up forever and ever, which lake of fire and brimstone is endless torment.

O then, my beloved brethren, repent ye, and enter in at the strait gate, and continue in the way which is narrow, until ye shall obtain eternal life.

O be wise; what can I say more?

Finally, I bid you farewell, until I shall meet you before the pleasing bar of God, which bar striketh the wicked with awful dread and fear. Amen.

## Иаков 7

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор хэдэн жил улиран одсоны дараа, Нифайн хүмүүсийн дунд Шерим хэмээн нэрлэгдсэн нэгэн хүн ирэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүсийн дунд номлож, мөн Христ байхгүй хэмээн тунхаглаж эхлэв. Мөн тэрээр хүмүүсийг зусардсан олон зүйл номлосон ажгуу; мөн Христийн сургаалыг устгаж болохын тулд тэр үүнийг хийсэн ажээ.
- 3 Мөн тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийг зайцуулан дагуулж болохын тулд тэрээр шаргуу хөдөлмөрлөсөн, үүнийхээ хэрээр тэр олон зүрх сэтгэлийг зайцуулсан ажээ; мөн би, Иаков, ирэх ёстой Христэд итгэлтэй гэдгийг мэдсэний учир, тэрээр над дээр ирэх боломжийг ихэд эрэлхийлж байв.
- 4 Мөн тэрээр эрдэмт нэгэн учир хүмүүний хэл ярианы төгс мэдлэгийг эзэмшсэн байв; иймийн тул, чөтгөрийн хүчний дагуу тэр ихээхэн зусардалтыг, мөн ярих ихээхэн хүчийг хэрэглэж чадсан ажгуу.
- 5 Мөн эдгээр зүйлүүдийн талаар миний үзсэн олон зүйл мөн олон илчлэлт байсан хэдий ч, тэрээр миний итгэлийг гуйвуулахаар найдаж байв; учир нь би үнэхээр тэнгэр элчүүдийг харж, мөн тэд надад тохиуулсан билээ. Мөн түүнчлэн, надад чухам тэр үгийг ярьсан Их Эзэний дуу хоолойг цагаас цагт би сонссон; иймийн тул, би гуйвуулагдаж чадахгүй бөлгөө.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэрээр надад ирж, мөн ийм янзаар тэрээр надад ярьж, хэлсэн нь: Иаков ахаа, би тантай ярих боломжийг ихэд эрэлхийлэв; учир нь та сайн мэдээ, эсвэл Христийн сургаал гэж нэрлэх тэрнийг номлон, ихэд явдгийг тань би сонссон мөн түүнчлэн мэднэ.
- 7 Мөн энэ хүмүүсийн олныг нь та зайцуулсан учир тэд Бурханы зөв замыг гажуудуулсан, мөн зөв зам болох Мосегийн хуулийг эс дагадаг; мөн Мосегийн хуулийг таны хэлдгээр одоогоос олон зуун жилийн хойно ирэх тэр хүнийг бишрэн шүтэхэд зориулан өөрчилдөг. Мөн эдүгээ болгоогтун, би, Шерим, энэ бол Бурханыг доромжилсон хэрэг гэдгийг танд мэдэгдэж байна; учир нь нэг ч хүн ийм зүйлийг эс мэднэ; учир нь болох зүйлийг тэр хэлж эс чадна. Мөн иймэрхүү маягаар Шерим миний эсрэг маргав.

## Jacob 7

- And now it came to pass after some years had passed away, there came a man among the people of Nephi, whose name was Sherem.
- And it came to pass that he began to preach among the people, and to declare unto them that there should be no Christ. And he preached many things which were flattering unto the people; and this he did that he might overthrow the doctrine of Christ.
- And he labored diligently that he might lead away the hearts of the people, insomuch that he did lead away many hearts; and he knowing that I, Jacob, had faith in Christ who should come, he sought much opportunity that he might come unto me.
- And he was learned, that he had a perfect knowledge of the language of the people; wherefore, he could use much flattery, and much power of speech, according to the power of the devil.
- And he had hope to shake me from the faith, notwithstanding the many revelations and the many things which I had seen concerning these things; for I truly had seen angels, and they had ministered unto me. And also, I had heard the voice of the Lord speaking unto me in very word, from time to time; wherefore, I could not be shaken.
- And it came to pass that he came unto me, and on this wise did he speak unto me, saying: Brother Jacob, I have sought much opportunity that I might speak unto you; for I have heard and also know that thou goest about much, preaching that which ye call the gospel, or the doctrine of Christ.
- And ye have led away much of this people that they pervert the right way of God, and keep not the law of Moses which is the right way; and convert the law of Moses into the worship of a being which ye say shall come many hundred years hence. And now behold, I, Sherem, declare unto you that this is blasphemy; for no man knoweth of such things; for he cannot tell of things to come. And after this manner did Sherem contend against me.

- 8 Гэвч болгоогтун, Их Эзэн Бурхан өөрийн Сүнснийг миний бодгальд юулж, үүний хэрээр би түүний бүх үгсийнх нь тул түүнийг ичгүүрлэсэн бөлгөө.
- 9 Мөн би түүнд хэлэв: Та ирэх Христийг үгүйсгэнэ үү? Мөн тэр хэлэв: Хэрэв Христ гэж байх аваас, би түүнийг үгүйсгэх нь үгүй; гэвч Христ байхгүйг гэдгийг би мэднэ, мөн байсан нь ч үгүй, бас хэзээ ч байх нь үгүй.
- 10 Мөн би түүнд: Судруудад та итгэдэг үү? гэв. Мөн тэр, Тийм гэв.
- 11 Мөн би түүнд хэлэв: Тэгвэл та тэдгээрийг ойлгодоггүй юм байна; учир нь тэдгээр нь үнэхээр Христийг гэрчилдэг. Болгоогтун, нэгээхэн ч бошиглогч тэдгээр нь энэхүү Христийн талаар л өгүүлснээс биш, юуг ч бошиглосон нь мөн бичсэн нь үгүйг би танд хэлнэ.
- 12 Мөн үүгээр ч зогсохгүй—энэ нь надад үзүүлэгдсэн, учир нь би сонсож бас үзсэн; мөн энэ нь түүнчлэн надад Ариун Сүнсний хүчээр үзүүлэгдсэн болой; иймийн тул, хэрэв цагаатгал үйлдэгдээгүй аваас бүх хүн төрөлхтөн төөрөлдөх ёстойг би мэднэ.
- 13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр надад хэлэв: Та тэгж сайн мэдэх түүгээр, Ариун Сүнсний хүчээр надад тэмдэг үзүүлээч.
- 14 Мөн би түүнд хэлэв: Үнэн гэдгийг нь таны мэдэх зүйлд танд тэмдэг үзүүлэхийн тулд Бурханыг сонжих би хэн билээ? Гэсэн ч та үүнийг үгүйсгэдэг, яагаад гэвэл та чөтгөрийнх учраас тэр. Гэсэн хэдий ч, миний хүсэл гүйцэлдэх нь үгүй; харин хэрэв Бурхан таныг цохивол, тэр нь тэнгэрт мөн газарт хүчтэй түүний танд үзүүлэх тэмдэг болог; мөн түүнчлэн, тэр нь Христ ирэх болно гэсний тэмдэг буюу. Мөн, гүйцэлдсэн байг, минийх бус харин таны таалал Ай Их Эзэн минь.
- 15 Мөнхүү улиран тохиох дор би, Иаков, эдгээр үгсийг ярьсны дараа, Их Эзэний хүч түүн дээр ирж, тэгээд тэр газарт унав. Мөнхүү улиран тохиох дор тэр олон өдрийн турш сувилуулсан бөлгөө.
- 16 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр хүмүүст: Маргааш нэгдэн цугларцгаа, учир нь би үхэх болно; иймийн тул, би үхэхээсээ өмнө хүмүүст ярихыг хүсч байна хэмээв.

But behold, the Lord God poured in his Spirit into my soul, insomuch that I did confound him in all his words.

And I said unto him: Deniest thou the Christ who shall come? And he said: If there should be a Christ, I would not deny him; but I know that there is no Christ, neither has been, nor ever will be.

And I said unto him: Believest thou the scriptures? And he said, Yea.

And I said unto him: Then ye do not understand them; for they truly testify of Christ. Behold, I say unto you that none of the prophets have written, nor prophesied, save they have spoken concerning this Christ.

And this is not all—it has been made manifest unto me, for I have heard and seen; and it also has been made manifest unto me by the power of the Holy Ghost; wherefore, I know if there should be no atonement made all mankind must be lost.

And it came to pass that he said unto me: Show me a sign by this power of the Holy Ghost, in the which ye know so much.

And I said unto him: What am I that I should tempt God to show unto thee a sign in the thing which thou knowest to be true? Yet thou wilt deny it, because thou art of the devil. Nevertheless, not my will be done; but if God shall smite thee, let that be a sign unto thee that he has power, both in heaven and in earth; and also, that Christ shall come. And thy will, O Lord, be done, and not mine.

And it came to pass that when I, Jacob, had spoken these words, the power of the Lord came upon him, insomuch that he fell to the earth. And it came to pass that he was nourished for the space of many days.

And it came to pass that he said unto the people: Gather together on the morrow, for I shall die; wherefore, I desire to speak unto the people before I shall die.

- 17 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь олон хүн нэгдэн цугларсан байв; мөн тэрээр тэдэнд тодорхойгоор ярьж мөн тэдэнд өөрийн заасан зүйлүүдээ үгүйсгэв, мөн Христийг, мөн Ариун Сүнсний хүчийг, мөн тэнгэр элчүүдийн тохинууллыг хүлээн зөвшөөрөв.
- 18 Мөн тэрээр чөтгөрийн хүчээр мэхлэгдсэн байснаа тэдэнд тодорхой яриу. Мөн тамын тухай, мөн үүрд мөнхийн тухай, мөн мөнхийн цээрлэлийн тухай тэрээр ярьсан бөлгөө.
- 19 Мөн тэрээр хэлэв: би Бурханд худал хэлсний учир, уучлагдашгүй нүгэл үйлдлээ хэмээн айж байна би; учир нь би Христийг үгүйсгэж, мөн би судруудаа итгэсэн хэмээн хэлсэн билээ; мөн тэдгээр нь үнэхээр түүнийг гэрчилдэг. Мөн би тийн Бурханд худлаа хэлсэн учир миний байдал аймшигтай байх болно хэмээн маш ихээр айж байна би; гэвч би Бурханд нүглээ хүлээсэн билээ.
- 20 Мөнхүү улиран тохиох дор тэр тэдгээр үгсийг хэлээд тэрээр өөр юу ч хэлж чадсангүй, мөн түүний сүнс зайллаа.
- 21 Мөн олон түмэн тэрээр бараг сүнс нь зайлж байхдаа эдгээр зүйлийг гэрчлэх болсонд, тэд үлэмж ихээр гайхан цочирдсон байв; үүний хэрээр Бурханы хүч тэдэн дээр доошлон ирж, мөн тэд газарт унатлаа тэгж давамгайлагдсан бөлгөө.
- 22 Эдүгээ, энэ нь Иаков надад тааламжтай байв, учир нь тэнгэр дэх Эцэгээсээ би үүнийг хүссэн юм; учир нь тэрээр миний гуйлтыг сонсож мөн миний залбиралд хариулсан бөлгөө.
- 23 Мөнхүү улиран тохиох дор Бурханы амар амгалан болон хайр хүмүүсийн дунд дахин сэргээгдсэн байв; мөн тэд судруудыг судалж, мөн ёс бус энэ хүний үгсийг дахин сонссонгүй.
- 24 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг үнэний мэдлэгт дахин оруулах хийгээд сэргээхийн тулд олон арга сэдэгдсэн байлаа; гэвч энэ бүгд талаар өнгөрөв, учир нь тэд дайнууд болон цусанд баясдаг байв, мөн өөрсдийнх нь ах дүүс болох бидний эсрэг мөнхийн үзэн ядалтыг агуулдаг байв. Мөн тэд зэвсгийнхээ хүчээр биднийг устгахыг үргэлж эрэлхийлж байв.

And it came to pass that on the morrow the multitude were gathered together; and he spake plainly unto them and denied the things which he had taught them, and confessed the Christ, and the power of the Holy Ghost, and the ministering of angels.

And he spake plainly unto them, that he had been deceived by the power of the devil. And he spake of hell, and of eternity, and of eternal punishment.

And he said: I fear lest I have committed the unpardonable sin, for I have lied unto God; for I denied the Christ, and said that I believed the scriptures; and they truly testify of him. And because I have thus lied unto God I greatly fear lest my case shall be awful; but I confess unto God.

And it came to pass that when he had said these words he could say no more, and he gave up the ghost.

And when the multitude had witnessed that he spake these things as he was about to give up the ghost, they were astonished exceedingly; insomuch that the power of God came down upon them, and they were overcome that they fell to the earth.

Now, this thing was pleasing unto me, Jacob, for I had requested it of my Father who was in heaven; for he had heard my cry and answered my prayer.

And it came to pass that peace and the love of God was restored again among the people; and they searched the scriptures, and hearkened no more to the words of this wicked man.

And it came to pass that many means were devised to reclaim and restore the Lamanites to the knowledge of the truth; but it all was vain, for they delighted in wars and bloodshed, and they had an eternal hatred against us, their brethren. And they sought by the power of their arms to destroy us continually.

25 Иймийн тул, Нифайн хүмүүс өөрсдийн авралын Бурханд болон хаданд итгэж, мөн өөрсдийн зэр зэвсэг, мөн өөрсдийн бүх хүч чадлаар тэдний эсрэг бэхлэн хамгаалсан билээ; иймийн тул, тэд одоохондоо дайснуудаа ялан дийлэгсэд болсон бөлгөө.

26 Мөнхүү улиран тохиох дор би, Иаков, өтөлж эхлэв; мөн энэ хүмүүсийн цэдэг Нифайн бусад ялтсууд дээр хадгалагдсан буй, иймийн тул, мэдлэгээ шавхсаны дагуу бичиглэсэнээ тунхаглав, би цаг хугацаа бидэнтэй хамт улиран одож, мөн түүнчлэн бидний амьдрал зүүдэнд байсан мэт улиран одож байна; учир нь бид ганцаардсан мөн чанд хүмүүс, бэдрэгсэд, Иерусалимаас хөөгдсөн, аглаг буйдад зовлон дунд төрсөн, түүнчлэн ах дүүсээрээ үзэн ядагдахын хэрээр дайн тэмцлийг өдөөгч болжээ хэмээн хэлснээр би энэхүү цэдгийг дуусгая; иймийн тул, бид өөрсдийн өдрүүдэд гашуудсаар байлаа.

27 Мөн би, Иаков, булшиндаа удахгүй доош орох ёстойгоо ойлгов; иймийн тул, би хүү Иностоо хэлэв: Эдгээр ялтсуудыг авагтун. Мөн миний ах Нифайн надад зарлигласан зүйлийг би түүнд хэлсэн, мөн зарлигуудад дуулгавартай байхаа тэрээр амласан бөлгөө. Мөн би багахныг бичиглэсэн буй эдгээр ялтсууд дээрх бичиглэлээ төгсгөл болгоё; мөн уншигчид би сайн сайхныг хүсч, ах дүүсийн маань олон нь миний үгсийг унших болов уу гэж найдъя, Ах дүүс минь, Бурхан та нартай хамт байг.

Wherefore, the people of Nephi did fortify against them with their arms, and with all their might, trusting in the God and rock of their salvation; wherefore, they became as yet, conquerors of their enemies.

And it came to pass that I, Jacob, began to be old; and the record of this people being kept on the other plates of Nephi, wherefore, I conclude this record, declaring that I have written according to the best of my knowledge, by saying that the time passed away with us, and also our lives passed away like as it were unto us a dream, we being a lonesome and a solemn people, wanderers, cast out from Jerusalem, born in tribulation, in a wilderness, and hated of our brethren, which caused wars and contentions; wherefore, we did mourn out our days.

And I, Jacob, saw that I must soon go down to my grave; wherefore, I said unto my son Enos: Take these plates. And I told him the things which my brother Nephi had commanded me, and he promised obedience unto the commands. And I make an end of my writing upon these plates, which writing has been small; and to the reader I bid farewell, hoping that many of my brethren may read my words. Brethren, adieu.

# ИНОСЫН НОМ

- 1 БОЛГООГТУН, мөнхүү улиран тохиох дор би, Инос, миний эцэг шударга хүн байсныг мэдэхийн учир—тэрээр надад өөрийн хэлээр, мөн түүнчлэн Их Эзэний халамж хийгээд зөвлөгөөнд заан хүмүүжүүлсэн болой—мөн үүний учир Бурханы минь нэр алдаршиг.
- 2 Мөн нүглийнхээ ангижралыг хүлээн авахаас өмнө, би Бурханы өмнө хэрхэн өөртэйгөө тэмцэлдсэнээ танд би хэлэх болно.
- 3 Болгоогтун, би ан агнахаар ойд очив; мөн мөнх амьдрал, бас гэгээнтнүүдийн баяслын талаар эцгийнхээ ярьж байхыг олонтаа сонссон тэр үгс, зүрх сэтгэлд минь гүнзгий шингэсэн байв.
- 4 Мөн бодгаль минь өлссөн байв; мөн намайг Бий Болгогчийн өмнө сөхөрсөн би, мөн хүчит залбирлаар мөн бодгалийнхаа төлөө гуйлтаар түүнээс гуйсан; мөн бүхэл өдрийн турш би түүнээс гуйв; тийм ээ, мөн шөнө ирэхэд би дуугаа өндөрсгөн үргэлжлүүлсээр байсан учир энэ нь тэнгэрт хүрсэн бөлгөө.
- 5 Мөн тэгтэл нэгэн дуу хоолой надад ирж, өгүүлсэн нь: Инос нүглүүд чинь өршөөгдсөн, мөн чи адислагдах болно хэмээв.
- 6 Мөн би, Инос, Бурхан худал хэлж эс чадахыг мэднэ; иймийн тул, миний гэм зайлуулагдсан бөлгөө.
- 7 Мөн би хэлэв: Их Эзэн, энэ хэрхэн бүтэв
- 8 Мөн тэрээр надад хэлэв: Чи урьд нь хэзээ ч сонсож бас хараагүй, Христэд итгэлтэйн чинь учир буюу. Мөн тэрээр өөрийгөө бие махбодид үзүүлэхээс өмнө олон жил улирч одно; иймийн тул, яв, итгэл чинь чамайг эдгээлээ.
- 9 Эдүгээ, улиран тохиох дор би эдгээр үгсийг сонсоод өөрийн ах дүү нар, нифайчуудын аз жаргалын төлөө хүслийг мэдэрч эхэллээ; иймийн тул, би тэдний төлөө бүх сэтгэл оюунаа Бурханд дэлгэсэн бөлгөө.

# The Book of Enos

Behold, it came to pass that I, Enos, knowing my father that he was a just man—for he taught me in his language, and also in the nurture and admonition of the Lord—and blessed be the name of my God for it—

And I will tell you of the wrestle which I had before God, before I received a remission of my sins.

Behold, I went to hunt beasts in the forests; and the words which I had often heard my father speak concerning eternal life, and the joy of the saints, sunk deep into my heart.

And my soul hungered; and I kneeled down before my Maker, and I cried unto him in mighty prayer and supplication for mine own soul; and all the day long did I cry unto him; yea, and when the night came I did still raise my voice high that it reached the heavens.

And there came a voice unto me, saying: Enos, thy sins are forgiven thee, and thou shalt be blessed.

And I, Enos, knew that God could not lie; wherefore, my guilt was swept away.

And I said: Lord, how is it done?

And he said unto me: Because of thy faith in Christ, whom thou hast never before heard nor seen. And many years pass away before he shall manifest himself in the flesh; wherefore, go to, thy faith hath made thee whole.

Now, it came to pass that when I had heard these words I began to feel a desire for the welfare of my brethren, the Nephites; wherefore, I did pour out my whole soul unto God for them.



10 Мөн намайг тийн оюун бодолдоо зүдрэн байхад, болгоогтун, Их Эзэний дуу хоолой миний ухаанд дахин ирж, өгүүлсэн нь: Зарлигуудыг минь дагах тэдний чармайлтын дагуу ах дүүст чинь би зочлох болно. Би тэдэнд энэ нутгийг өгсөн билээ, мөн энэ нь ариун нутаг; мөн алдсын учир бус аваас би үүнийг зүхэх нь үгүй; иймийн тул, би хэлснийхээ дагуу ах дүүст чинь зочлох болно; мөн тэдний зөрчлүүдийг өөрсдийнх нь толгой дээрх харууслын хамт би доош авчрах болно.

11 Мөн би, Инос, эдгээр үгсийг сонссоны дараа, Их Эзэнд итгэх итгэл минь гуйвшгүй болж эхлэв; мөн би өөрийн ахан дүүс, леменчүүдийн төлөө удаан хуцаагаар олон зүдрэлтэйгээр түүнд залбирав.

12 Мөнхүү улиран тохиох дор би залбирч мөн бүх хүчээрээ чармайн хөдөлмөрлөсний дараа, Их Эзэн надад: итгэлийн чинь учир, хүслийн чинь дагуу би чамд өгнө хэмээв.

13 Мөн эдүгээ болгоогтун, түүнээс миний хүссэн тэрхүү хүсэл ийм байв—хэрэв миний хүмүүс, нифайчууд, зөрчилд унаж мөн ямар нэгэн байдлаар устгагдах бол, мөн леменчүүд устгагдахгүй байх аваас Их Эзэн Бурхан нифайчууд болох миний хүмүүсийн цэдгийг хадгалан үлдээх болгоосой хэмээн; бүр хэрэв түүний ариун мутрын хүчээр байсан ч, энэ нь хэрэв нэгэн ирээдүйн өдөр леменчүүдэд, тэд авралд авчрагдаж болохын тулд гаргагдаж болно хэмээсэн буюу—

14 Учир нь одоо бол тэднийг үнэн итгэлд сэргээх гэсэн бидний зүтгэлүүд талаар болсон ажгуу. Мөн хэрэв энэ нь боломжтой байсан бол, тэд бидний цэдгүүдийг мөн биднийг, мөн түүнчлэн бидний эцэг өвгөдийн бүх заншил уламжлалуудыг устгахаар тэд уурандаа ам алдсан бөлгөө.

15 Иймийн тул, Их Эзэн Бурхан бидний цэдгүүдийг хадгалан үлдээх боломжтойг би мэдсэний учир, би түүнээс үргэлж гуйв, учир нь тэрээр надад: Чи Христийн нэрээр хүлээн авах болно хэмээн найдаж итгэлтэйгээр гуйсан юуг ч болов, чи хүлээн авах болно хэмээн хэлсэн болой.

16 Мөн надад итгэл байж, мөн би Бурханд тэрээр цэдгүүдийг хадгалан үлдээхийг гуйсан болой; мөн тэрээр тэдгээрийг зохих цагт нь леменчүүдэд авчрах болно хэмээн надтай гэрээлсэн бөлгөө.

And while I was thus struggling in the spirit, behold, the voice of the Lord came into my mind again, saying: I will visit thy brethren according to their diligence in keeping my commandments. I have given unto them this land, and it is a holy land; and I curse it not save it be for the cause of iniquity; wherefore, I will visit thy brethren according as I have said; and their transgressions will I bring down with sorrow upon their own heads.

And after I, Enos, had heard these words, my faith began to be unshaken in the Lord; and I prayed unto him with many long strugglings for my brethren, the Lamanites.

And it came to pass that after I had prayed and labored with all diligence, the Lord said unto me: I will grant unto thee according to thy desires, because of thy faith.

And now behold, this was the desire which I desired of him—that if it should so be, that my people, the Nephites, should fall into transgression, and by any means be destroyed, and the Lamanites should not be destroyed, that the Lord God would preserve a record of my people, the Nephites; even if it so be by the power of his holy arm, that it might be brought forth at some future day unto the Lamanites, that, perhaps, they might be brought unto salvation—

For at the present our strugglings were vain in restoring them to the true faith. And they swore in their wrath that, if it were possible, they would destroy our records and us, and also all the traditions of our fathers.

Wherefore, I knowing that the Lord God was able to preserve our records, I cried unto him continually, for he had said unto me: Whatsoever thing ye shall ask in faith, believing that ye shall receive in the name of Christ, ye shall receive it.

And I had faith, and I did cry unto God that he would preserve the records; and he covenanted with me that he would bring them forth unto the Lamanites in his own due time.

17 Мөн би, Инос, энэ нь түүний хийсэн тэрхүү гэрээний дагуу байхыг мэдсэн бөлгөө; иймийн тул, бодгаль минь амрав.

18 Мөн Их Эзэн надад хэлэв: Чиний эцэг өвгөд түүнчлэн энэ зүйлийг надаас хүссэн юм; мөн энэ нь тэдний итгэлийн дагуу гүйцэлдэх болно; учир нь тэдний итгэл чинийх лугаа адил байсан бөлгөө.

19 Мөнхүү улиран тохиох дор би, Инос, ирэх зүйлийг бошиглон, мөн өөрийн сонссон мөн үзсэн зүйлийг гэрчлэн Нифайн хүмүүсийн дунд одсон бөлгөө.

20 Мөн Нифайн хүмүүс леменчүүдийг Бурханы үнэн итгэлд сэргээхээр чармайн эрэлхийлснийг би гэрчилж байна. Гэвч бидний хөдөлмөр талаар өнгөрсөн билээ; тэдний үзэн ядалт нь хөдөлгөөнгүй бэхэжсэн юм, мөн тэд хилэнцэт байдалдаа удирдагдсан учир тэд зэрлэг, мөн догшин ширүүн, мөн цусанд дуртай хүмүүс болж, хиймэл шүтээн хийгээд бузар байдлаар дүүрсэн болой; агнасан амьтдаараа хооллон; майханд амьдарч, мөн хэвлийн тус газраараа богино арьс бүслэн мөн үсээ хусуулж аглаг буйдад хэрэн бэдрэх бөлгөө; мөн тэдний чадвар нь нум суманд, мөн тахир сэлэм, мөн сүхэнд байлаа. Мөн тэдний олон нь түүхий махнаас өөр юуг ч эс иддэг; мөн тэд биднийг устгахаар үргэлж эрэлхийлдэг болой.

21 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүс газар боловсруулж, мөн бүх төрлийн будаа тариа, мөн жимс ургуулж, мөн мал сүргийг, мөн янз бүрийн үхэр малыг төрөл төрлөөр нь, мөн ямаа, бас зэрлэг ямаа, мөн түүнчлэн олон адуу өсгөдөг болсон ажээ.

22 Мөн үлэмж олон бошиглогч бидний дунд байв. Мөн хүмүүс нь зөрүүд, ойлгохдоо хэцүү хүмүүс байв.

23 Мөн үлэмж хэрцгий авир, дайнууд мөн тэмцлүүд, мөн устгалуудын талаар номлож мөн бошиглохоос, мөн үхлийг, мөн мөнхийн хугацааг, мөн Бурханы хүч болон шийтгэлүүд, мөн эдгээр бүх зүйлийг үргэлж сануулахаас—тэднийг Их Эзэнээс эмээх айдаст байлгахын тулд үргэлж бусниулахаас бусдаар бол юу ч байсангүй. Тэднийг устгал уруу доош хурдан явахаас хамгаалах эдгээр зүйлүүдээс, мөн ярихдаа үлэмж агуу тодорхой байхаас өөр юу ч эс байсныг хэлнэ би. Мөн ийм маягаар тэдний талаар бичиглэх буюу би.

And I, Enos, knew it would be according to the covenant which he had made; wherefore my soul did rest.

And the Lord said unto me: Thy fathers have also required of me this thing; and it shall be done unto them according to their faith; for their faith was like unto thine.

And now it came to pass that I, Enos, went about among the people of Nephi, prophesying of things to come, and testifying of the things which I had heard and seen.

And I bear record that the people of Nephi did seek diligently to restore the Lamanites unto the true faith in God. But our labors were vain; their hatred was fixed, and they were led by their evil nature that they became wild, and ferocious, and a blood-thirsty people, full of idolatry and filthiness; feeding upon beasts of prey; dwelling in tents, and wandering about in the wilderness with a short skin girdle about their loins and their heads shaven; and their skill was in the bow, and in the cimeter, and the ax. And many of them did eat nothing save it was raw meat; and they were continually seeking to destroy us.

And it came to pass that the people of Nephi did till the land, and raise all manner of grain, and of fruit, and flocks of herds, and flocks of all manner of cattle of every kind, and goats, and wild goats, and also many horses.

And there were exceedingly many prophets among us. And the people were a stiffnecked people, hard to understand.

And there was nothing save it was exceeding harshness, preaching and prophesying of wars, and contentions, and destructions, and continually reminding them of death, and the duration of eternity, and the judgments and the power of God, and all these things—stirring them up continually to keep them in the fear of the Lord. I say there was nothing short of these things, and exceedingly great plainness of speech, would keep them from going down speedily to destruction. And after this manner do I write concerning them.

- 24 Мөн нифайчууд бас леменчүүдийн хоорондоо дайтахыг амьдралынхаа өдрүүдэд үзсэн болой би.
- 25 Мөнхүү улиран тохиох дор би өтөлж эхлэв, мөн бидний өвөг Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас нэг зуун далан есөн жил улиран оджээ.
- 26 Мөн би удахгүй доош булшиндаа орох ёстойгоо мэдэв, мөн Бурханы хүч над дээр үйлдсэн учир би энэ хүмүүст номлож мөн бошиглон, мөн Христ дэх тэрхүү үнэний дагуу үгийг тунхаглах ёстой байв. Мөн би үүнийг бүх өдрүүдийнхээ турш тунхагласан мөн дэлхийнхээс илүүгээр үүнд баяссан бөлгөө.
- 27 Мөн би Гэтэлгэгчтэйгээ хамт байх тэрхүү амрах газартаа удахгүй явна; учир нь би түүнд амрах болно гэдгээ мэднэ. Мөн зуурдын бие нь үхэшгүйг өмсөх тэр өдөр баясна би, мөн түүний өмнө зогсох болно, тэгээд түүний царайг тааламжтайгаар харж, мөн тэрээр надад: Надад ирэгтүн, адислагдсан болой чи, миний Эцгийн харшуудад чамд зориулан бэлтгэгдсэн байр буй гэж хэлэх болно. Амен.

And I saw wars between the Nephites and Lamanites in the course of my days.

And it came to pass that I began to be old, and an hundred and seventy and nine years had passed away from the time that our father Lehi left Jerusalem.

And I saw that I must soon go down to my grave, having been wrought upon by the power of God that I must preach and prophesy unto this people, and declare the word according to the truth which is in Christ. And I have declared it in all my days, and have rejoiced in it above that of the world.

And I soon go to the place of my rest, which is with my Redeemer; for I know that in him I shall rest. And I rejoice in the day when my mortal shall put on immortality, and shall stand before him; then shall I see his face with pleasure, and he will say unto me: Come unto me, ye blessed, there is a place prepared for you in the mansions of my Father. Amen.

# ЖЕРОМЫН НОМ

- 1 ЭДҮГЭЭ болгоогтун, би, Жером, эцэг Иносынхоо зарлигийн дагуу бидний удмын бичиг хадгалагдаж болохын тулд хэдэн үг бичье.
- 2 Мөн эдгээр ялтсууд жижиг учир мөн эдгээр зүйлүүд бидний ах дүүс леменчүүдийн тусын тулд бичигдсэн учир, иймийн тул, би багыг бичих нь зайлшгүй хэрэгтэй; гэвч би өөрийн бошиглол, бас өөрийн илчлэлтүүдийн зүйлүүдийг бичих нь үгүй. Учир нь эцэг өвгөдийнхөө бичиглэснээс илүү юуг би бичиж чадахсан билээ? Учир нь тэд авралын төлөвлөгөөг илчилсэн бус уу? Би та нарт хэлнэ, Тийм ээ; мөн энэ нь надад хангалттай.
- 3 Болгоогтун, тэдний зүрх сэтгэл хатуу, мөн сонор нь дүлий, мөн оюун нь харалган, мөн хүзүү нь гэжүүд Иудейн учир, энэ хүмүүсийн дунд их зүйл хийгдэх нь зүйд нийцнэ; гэсэн хэдий ч Бурхан бол тэдэнд үлэмжийн нигүүлсэнгүй, мөн өдий болтол тэднийг энэ газрын гадаргуугаас хараахан арчиж зайлуулаагүй байгаа билээ.
- 4 Мөн олон илчлэлт авсан нь бидний дунд олон буй, учир нь тэд бүгд гэжүүд бус. Мөн гэжүүд бус нь мөн итгэлийг агуулах тэд байж, итгэлийнх нь дагуу хүмүүний үрсэд үзүүлэх тэрхүү, Ариун Сүнстэй тэд харьцах бөлгөө.
- 5 Мөн эдүгээ, болгоогтун, хоёр зуун жил улиран одов, мөн Нифайн хүмүүс уг нутагт хүчирхэг болсон бөлгөө. Тэд Мосегийн хуулийг дагаж мөн хүндэтгэлийн өдрийг Их Эзэнд ариунаар хадгалахаар хичээсэн билээ. Мөн тэд Бурханыг хараах нь үгүй; бас тэд түүнийг доромжлох нь ч үгүй. Мөн уг нутгийн хуулиуд үлэмж чанд байв.
- 6 Мөн тэд, мөн Леменчүүд ч түүнчлэн энэ газрын гадаргуу дээр ихэд тархсан байв. Мөн тэд нифайчуудаас тоогоор үлэмж давуу байв; мөн тэд аллагад дурлаж мөн адгуусны цус уух бөлгөө.

# The Book of Jarom

Now behold, I, Jarom, write a few words according to the commandment of my father, Enos, that our genealogy may be kept.

And as these plates are small, and as these things are written for the intent of the benefit of our brethren the Lamanites, wherefore, it must needs be that I write a little; but I shall not write the things of my prophesying, nor of my revelations. For what could I write more than my fathers have written? For have not they revealed the plan of salvation? I say unto you, Yea; and this sufficeth me.

Behold, it is expedient that much should be done among this people, because of the hardness of their hearts, and the deafness of their ears, and the blindness of their minds, and the stiffness of their necks; nevertheless, God is exceedingly merciful unto them, and has not as yet swept them off from the face of the land.

And there are many among us who have many revelations, for they are not all stiffnecked. And as many as are not stiffnecked and have faith, have communion with the Holy Spirit, which maketh manifest unto the children of men, according to their faith.

And now, behold, two hundred years had passed away, and the people of Nephi had waxed strong in the land. They observed to keep the law of Moses and the sabbath day holy unto the Lord. And they profaned not; neither did they blaspheme. And the laws of the land were exceedingly strict.

And they were scattered upon much of the face of the land, and the Lamanites also. And they were exceedingly more numerous than were they of the Nephites; and they loved murder and would drink the blood of beasts.

- 7 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчууд бидний эсрэг тулалдахаар олон удаа ирэв. Гэвч манай хаад мөн бидний удирдагчид Их Эзэнд итгэх итгэлдээ хүчирхэг хүмүүс байв; мөн тэд Их Эзэний замуудыг хүмүүст заадаг байлаа; иймийн тул, бид леменчүүдийн эсрэг зогсож мөн тэднийг нутгаасаа хөөн зайлуулж, мөн хотуудаа, эсвээс бидний өв болох аливаа газрыг бэхлэн хамгаалж эхлэв.
- 8 Мөн бид үлэмж өнөр өтгөн болж, мөн газрын гадаргуугаар нэг тархав, мөн алт, мөн мөнгө, мөн үнэт зүйлүүд, мөн сайн хийцэт модон урлал, барилгууд, бас хөдөлгүүр, мөн түүнчлэн төмөр болон зэс, мөн гууль болон ган, газар боловсруулах бүх төрлийн янз бүрийн хэрэгслүүд, мөн дайны зэвсэг—тийм ээ, хурц үзүүрт сум, мөн чичлүүр, мөн хатгуур сум, мөн жад, бас дайны бүх бэлтгэлүүдээр үлэмж баян болсон байв.
- 9 Мөн тийн леменчүүдтэй тулахаар бэлтгэсэн байсан учир, тэд бидний эсрэг амжилт олсонгүй. Харин бидний эцэг өвгөдөд тэрээр ярьж, өгүүлсэн нь: Миний зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно хэмээсэн Их Эзэний үг нотлогдсон билээ.
- 10 Мөнхүү улиран тохиох дор хэрэв тэд зарлигуудыг эс дагаж, харин зөрчилд унавал, тэд энэ газрын гадаргуугаас устгагдах ёстой гэсэн Бурханы үгийн дагуу Их Эзэний бошиглогчид Нифайн хүмүүст сануулж байсан бөлгөө.
- 11 Иймийн тул, бошиглогчид, мөн санваартнууд, мөн багш нар, бүх зүтгэлээрээ чармайхыг хүмүүст тэвчээртэйгээр ухуулж, шаргуу хөдөлмөрлөж байв; Мосегийн хуулийг мөн үүний өгөгдсөн учрыг анхааруулан сургасан ажгуу; Мессиаг харж хүлээхийг тэдэнд ятган мөн тэрээр аль хэдийн байсан хэдий ч, түүнийг ирнэ гэдэгт итгэхийг ятгаж байв. Мөн ийм маягаар тэд тэдэнд зааж байлаа.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнчлэн үйлдсэнээр тэднийг энэ газрын гадаргуу дээр устгагдахаас ангижруулсан юм; учир нь тэд үгээр тэдний зүрхийг зүсэж, үргэлж бусниулан наманчлалд хүргэж байв.
- 13 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун гучин найман жил улиран одож—дайнууд, мөн тэмцлүүд, мөн маргаанууд цагийн ихийг эзэлсэн байв.

And it came to pass that they came many times against us, the Nephites, to battle. But our kings and our leaders were mighty men in the faith of the Lord; and they taught the people the ways of the Lord; wherefore, we withstood the Lamanites and swept them away out of our lands, and began to fortify our cities, or whatsoever place of our inheritance.

And we multiplied exceedingly, and spread upon the face of the land, and became exceedingly rich in gold, and in silver, and in precious things, and in fine workmanship of wood, in buildings, and in machinery, and also in iron and copper, and brass and steel, making all manner of tools of every kind to till the ground, and weapons of war—yea, the sharp pointed arrow, and the quiver, and the dart, and the javelin, and all preparations for war.

And thus being prepared to meet the Lamanites, they did not prosper against us. But the word of the Lord was verified, which he spake unto our fathers, saying that: Inasmuch as ye will keep my commandments ye shall prosper in the land.

And it came to pass that the prophets of the Lord did threaten the people of Nephi, according to the word of God, that if they did not keep the commandments, but should fall into transgression, they should be destroyed from off the face of the land.

Wherefore, the prophets, and the priests, and the teachers, did labor diligently, exhorting with all long-suffering the people to diligence; teaching the law of Moses, and the intent for which it was given; persuading them to look forward unto the Messiah, and believe in him to come as though he already was. And after this manner did they teach them.

And it came to pass that by so doing they kept them from being destroyed upon the face of the land; for they did prick their hearts with the word, continually stirring them up unto repentance.

And it came to pass that two hundred and thirty and eight years had passed away—after the manner of wars, and contentions, and dissensions, for the space of much of the time.

14 Мөн би, Жером, илүүг бичих нь үгүй, учир нь ялтсууд жижиг болой. Гэвч болгоогтун, ах дүүс минь, та нар Нифайн бусад ялтсуудаас лавлан үзэж болно; учир нь болгоогтун, тэдгээрийн дээр хаадын бичиглэлийн дагуу, эсвээс тэдний бичүүлсэн тэдгээр дайнуудын маань тухай цэдгүүд сийлэгдсэн буй.

15 Мөн би эдгээр ялтсуудыг хүү Омнаинхаа гарт, тэдгээр нь миний өвгөдийн зарлигуудын дагуу хадглагдаж болохын тулд шилжүүлэх бөлгөө.

And I, Jarom, do not write more, for the plates are small. But behold, my brethren, ye can go to the other plates of Nephi; for behold, upon them the records of our wars are engraven, according to the writings of the kings, or those which they caused to be written.

And I deliver these plates into the hands of my son Omni, that they may be kept according to the commandments of my fathers.

# ОМНАИН НОМ

- 1 БОЛГООГТУН, улиран тохиох дор би, Омнай, өөрийн эцэг, Жеромоор, би эдгээр ялтсууд дээр удмынхаа зарим нэгэн бичгийг хадгалж үлдээхийн тулд үргэлжлүүлэн бичих ёстой хэмээн зарлигдуулсан учир—
- 2 Иймийн тул, миний өдрүүдэд, би өөрийн хүмүүс, нифайчуудыг өөрсдийн дайснууд леменчүүдийн гарт орохоос хамгаалахын тулд би илдээр ихэд тулалдсаныг та нар мэдээсэй хэмээнэ. Гэвч болгоогтун, би өөрөө бол хилэнцэт нэгэн, мөн би Их Эзэний зарчмууд мөн зарлигуудыг зохих ёсоор дагасан нь үгүй.
- 3 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун далан зургаан жил улирч одов, мөн бид амар амгалангийн олон улирлыг үдлээ; мөн бидэнд хүнд хэцүү дайн мөн цус урсгасан олон улирал тохиосон бөлгөө. Тийм ээ, мөн эцэст нь, хоёр зуун наян хоёр жил улирч одлоо, мөн эцэг өвгөдийнхөө зарлигуудын дагуу эдгээр ялтсуудыг би хадгалсан билээ; мөн тэдгээрийг би хүү Амарондаа даатган шилжүүлэв. Ингээд би төгсгөө.
- 4 Мөн эдүгээ би, Амарон эцгийнхээ номонд өөрийн бичих цөөн зүйлийг бичье.
- 5 Болгоогтун, улиран тохиох дор гурван зуун хорин жил улирч, мөн нифайчуудын илүү ёс бус хэсэг нь устгагдсан бөлгөө.
- 6 Учир нь Их Эзэн тэвчсэнгүй, тэрээр тэднийг Иерусалимаас удирдан гаргаад мөн тэднийг дайсныхаа гарт орохоос нь хамгаалж, хадгалсны дараа, тийм ээ, бидний эцэг өвгөдөд тэрбээр ярьсан нь: Та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар уг нутагт хөгжин дэвжихгүй гэсэн тэрхүү үгс нотлогдохгүй байхыг тэрээр тэвчихгүй.
- 7 Иймийн тул, Их Эзэн тэдэнд агуу шийтгэлээр зочилсон ажгуу; гэсэн хэдий ч, тэрээр зөв шударгыг үйлдэгчид мөхөхгүй байхын тулд хэлтрүүлсэн, харин тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлсөн билээ.
- 8 Мөнхүү улиран тохиох дор би уг ялтсуудыг дүү Чемишдээ дамжуулан өглөө.

# The Book of Omni

Behold, it came to pass that I, Omni, being commanded by my father, Jarom, that I should write somewhat upon these plates, to preserve our genealogy—

Wherefore, in my days, I would that ye should know that I fought much with the sword to preserve my people, the Nephites, from falling into the hands of their enemies, the Lamanites. But behold, I of myself am a wicked man, and I have not kept the statutes and the commandments of the Lord as I ought to have done.

And it came to pass that two hundred and seventy and six years had passed away, and we had many seasons of peace; and we had many seasons of serious war and bloodshed. Yea, and in fine, two hundred and eighty and two years had passed away, and I had kept these plates according to the commandments of my fathers; and I conferred them upon my son Amaron. And I make an end.

And now I, Amaron, write the things whatsoever I write, which are few, in the book of my father.

Behold, it came to pass that three hundred and twenty years had passed away, and the more wicked part of the Nephites were destroyed.

For the Lord would not suffer, after he had led them out of the land of Jerusalem and kept and preserved them from falling into the hands of their enemies, yea, he would not suffer that the words should not be verified, which he spake unto our fathers, saying that: Inasmuch as ye will not keep my commandments ye shall not prosper in the land.

Wherefore, the Lord did visit them in great judgment; nevertheless, he did spare the righteous that they should not perish, but did deliver them out of the hands of their enemies.

And it came to pass that I did deliver the plates unto my brother Chemish.

9 Эдүгээ би, Чемиш, өөрийнхөө бичих цөөн зүйлийг ахынхаа бичсэнтэй адилаар уг номонд бичиглэв; учир нь болгоогтун, би түүний бичсэний сүүлчийг, тэрээр үүнийг өөрийн гараар бичсэнийг харсан билээ; мөн тэр тэдгээрийг надад дамжуулсан тэр өдөр үүнийг бичсэн бөлгөө. Мөн ийм маягаар бид цэдгүүдийг хадгалдаг, учир нь бидний эцэг өвгөдийн зарлигуудын дагуу буюу. Мөн би төгсгөлийг үйлдье.

10 Болгоогтун, би, Абинадом, Чемишийн хүү билээ. Болгоогтун, улиран тохиох дор миний хүмүүс болох нифайчууд, мөн леменчүүдийн хооронд болсон их дайн хийгээд тэмцлүүдийг би үзэв; мөн би, илдээрээ, ах дүүсээ өмгөөлөн олон леменчүүдийн амийг авсан билээ.

11 Мөн болгоогтун, энэ хүмүүсийн цэдэг үеэс үед дамжин, хаадад байх ялтсууд дээр сийлэгдсэн бөлгөө; мөн би бичиглэгдсэнээс гадуур ямар ч илчлэлт бас бошиглолыг эс мэднэ; иймийн тул, хангалттай нь бичигдсэн болой. Мөн би төгсгөлийг үйлдье.

12 Болгоогтун, би Амаликай, Абинадомын хүү болой. Болгоогтун, Зарахемлагийн нутагт хаан суулгагдсан Мозаягийн талаар зарим зүйлийг би та нарт ярих болно; учир нь болгоогтун, түүнийг Нифайн нутгаас зугтан гарвал зохино гэж мөн Их Эзэний дуу хоолойг сонсох тэр бүгд түүнчлэн түүнтэй хамт аглаг буйдад одвол зохино хэмээн тэрээр Их Эзэнээр сэрэмжлүүлэгдсэн учир—

13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Их Эзэн түүнд зарлигласны дагуу үйлдсэн болой. Мөн Их Эзэний дуу хоолойг сонссон болгон, тэд уг нутгаас аглаг буйдад зайлан одов; мөн тэд олон сургаал мөн бошиглолуудаар удирдагддаг байсан бөлгөө. Мөн тэд үргэлж Бурханы үгээр сургагдсан байв; мөн тэд аглаг буйдын дундуур Зарахемлагийн нутаг гэж нэрлэгдсэн тэр нутагт тэд уруудан иртлээ түүний мутрын хүчээр удирдагдсан ажээ.

14 Мөн тэд Зарахемлагийн хүмүүс гэж нэрлэгдсэн, тэрхүү хүмүүсийг олж мэдэв. Эдүгээ, Зарахемлагийн хүмүүсийн дунд агуу их баяр хөөр байв; мөн Их Эзэн Мозаягийн хүмүүсийг иудейчүүдийн цэдгийг агуулсан гуулин ялтсуудын хамт илгээсний учир, Зарахемла түүнчлэн үлэмж баяртай байв.

Now I, Chemish, write what few things I write, in the same book with my brother; for behold, I saw the last which he wrote, that he wrote it with his own hand; and he wrote it in the day that he delivered them unto me. And after this manner we keep the records, for it is according to the commandments of our fathers. And I make an end.

Behold, I, Abinadom, am the son of Chemish. Behold, it came to pass that I saw much war and contention between my people, the Nephites, and the Lamanites; and I, with my own sword, have taken the lives of many of the Lamanites in the defence of my brethren.

And behold, the record of this people is engraven upon plates which is had by the kings, according to the generations; and I know of no revelation save that which has been written, neither prophecy; wherefore, that which is sufficient is written. And I make an end.

Behold, I am Amaleki, the son of Abinadom. Behold, I will speak unto you somewhat concerning Mosiah, who was made king over the land of Zarahemla; for behold, he being warned of the Lord that he should flee out of the land of Nephi, and as many as would hearken unto the voice of the Lord should also depart out of the land with him, into the wilderness—

And it came to pass that he did according as the Lord had commanded him. And they departed out of the land into the wilderness, as many as would hearken unto the voice of the Lord; and they were led by many preachings and prophesyings. And they were admonished continually by the word of God; and they were led by the power of his arm, through the wilderness until they came down into the land which is called the land of Zarahemla.

And they discovered a people, who were called the people of Zarahemla. Now, there was great rejoicing among the people of Zarahemla; and also Zarahemla did rejoice exceedingly, because the Lord had sent the people of Mosiah with the plates of brass which contained the record of the Jews.



- 15 Болгоогтун, улиран тохиох дор Иудейн хаан, Зедикая Вавилонд боолчлолд аваачигдсан тэр үед Зарахемлагийн хүмүүс Иерусалимаас гарч ирснийг Мозая олж мэдэв.
- 16 Мөн тэд аглаг буйдад аялж, мөн Их Эзэний мутраар их усыг туулан Мозая тэднийг олсон тэр нутагт авчрагдсан байлаа; мөн тэд тэр цагаас хойш тэнд оршин суусан бөлгөө.
- 17 Мөн Мозая тэднийг олсон тэр цагт, тэд тоолшгүй олон болсон байв. Гэсэн хэдий ч, тэдэнд олон дайн мөн ширүүн тэмцлүүд байв, мөн цагаас цагт илдэнд эрсдэж унасаар байжээ; мөн тэдний хэл гуйвуулагджээ; мөн тэд өөрсөдтэйгөө цэдгүүдийг авчирсан нь үгүй; мөн тэд өөрсдийг нь Бүтээгч байдгийг үгүйсгэсэн бөлгөө; мөн тэднийг Мозая ч, бас Мозаягийн хүмүүс ч ойлгож эс чадсан буюу.
- 18 Гэвч улиран тохиох дор Мозая, тэд түүний хэлийг заалгавал зохино хэмээв. Мөнхүү улиран тохиох дор тэд Мозаягийн хэлийг заалгасны дараа, Зарахемла эцэг өвгөдийнхөө уг удмыг дурсамжийнхаа дагуу өгөв; мөн тэдгээр нь бичигдсэн, харин эдгээр ялтсуудад бус болой.
- 19 Мөнхүү улиран тохиох дор Зарахемлагийн мөн Мозаягийн хүмүүс хамтран нэгдэв; мөн Мозая тэдний хаан байхаар тохоогдов.
- 20 Мөнхүү улиран тохиох дор Мозаягийн өдрүүдэд, дээр нь сийлбэр бүхий том чулуу байсан нь түүнд авчрагдсан байв; мөн тэрээр уг сийлбэрийг Бурханы бэлэг болон хүчээр хөрвүүлсэн бөлгөө.
- 21 Мөн тэдгээр нь Кориантумр гэгч нэгний мөн түүний хүмүүсийн алагдагсдын шастирыг өгүүлэв. Мөн Кориантумр нь Зарахемлагийн хүмүүсээр олж мэдэгдсэн байв; мөн тэрээр тэдэнтэй есөн сарын турш оршсон буюу.
- 22 Энэ нь түүнчлэн түүний эцэг өвгөдийн талаар цөөн үгсийг өгүүлсэн бөлгөө. Мөн түүний анхны эцэг эх нь Их Эзэн хүмүүсийн хэлийг будлиулсан тэр цагт, уг цамхаас ирсэн буюу; мөн Их Эзэний ял түүний шударга шүүлтийн дагуу тэдэн дээр оногдсон ажгуу; мөн тэдний яснууд нутгийн умардад таран хэвтэх аж.

Behold, it came to pass that Mosiah discovered that the people of Zarahemla came out from Jerusalem at the time that Zedekiah, king of Judah, was carried away captive into Babylon.

And they journeyed in the wilderness, and were brought by the hand of the Lord across the great waters, into the land where Mosiah discovered them; and they had dwelt there from that time forth.

And at the time that Mosiah discovered them, they had become exceedingly numerous. Nevertheless, they had had many wars and serious contentions, and had fallen by the sword from time to time; and their language had become corrupted; and they had brought no records with them; and they denied the being of their Creator; and Mosiah, nor the people of Mosiah, could understand them.

But it came to pass that Mosiah caused that they should be taught in his language. And it came to pass that after they were taught in the language of Mosiah, Zarahemla gave a genealogy of his fathers, according to his memory; and they are written, but not in these plates.

And it came to pass that the people of Zarahemla, and of Mosiah, did unite together; and Mosiah was appointed to be their king.

And it came to pass in the days of Mosiah, there was a large stone brought unto him with engravings on it; and he did interpret the engravings by the gift and power of God.

And they gave an account of one Coriantumr, and the slain of his people. And Coriantumr was discovered by the people of Zarahemla; and he dwelt with them for the space of nine moons.

It also spake a few words concerning his fathers. And his first parents came out from the tower, at the time the Lord confounded the language of the people; and the severity of the Lord fell upon them according to his judgments, which are just; and their bones lay scattered in the land northward.

- 23 Болгоогтун, би, Амаликай, Мозаягийн өдрүүдэд төрсөн билээ; мөн би түүний үхлийг үзтэлээ амьдарч байв; мөн түүний хүү, Бенжамин, түүний оронд засаглан суух бөлгөө.
- 24 Мөн болгоогтун, хаан Бенжаминны өдрүүдэд, нифайчууд мөн леменчүүдийн дунд ширүүн дайн мөн их цус урсахыг би үзэв. Гэвч болгоогтун, Нифайчууд тэднийг ихэд давамгайлах байдалд хүрэв; тийм ээ, үүний хэрээр хаан Бенжамин тэднийг Зарахемлагийн нутгаас зайлуулан гаргасан бөлгөө.
- 25 Мөнхүү улиран тохиох дор би өтөлж эхлэв; мөн үр удам үгүй байв, мөн хаан Бенжамин Их Эзэний өмнө шударга хүн болохыг мэдэхийн учир, иймийн тул, би эдгээр ялтсуудыг түүнд дамжуулан, бүх хүмүүнийг Израилын Ариун Нэгэн, Бурханд ирж, мөн бошиглолуудад мөн илчлэлтүүдэд, мөн тэнгэр элчүүдийн тохинуулалд, мөн хэлээр ярихын бэлэгт, мөн хэлийг хөрвүүлэхийн бэлэгт мөн сайн болох тэр бүх зүйлүүдэд итгэхийг ятгах болно; учир нь Их Эзэнээс ирээгүй л бол ямар ч сайн нь үгүй: мөн хилэнцэт тэр нь чөтгөрөөс ирдэг бөлгөө.
- 26 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, та нарыг Израилын Ариун Нэгэн болох Христэд ирж, мөн түүний авралаас мөн түүний гэтэлгэлийн хүчнээс хүртээсэй хэмээнэ би. Тийм ээ, түүнд ирэгтүн, мөн өөрийн бүхэл бодгалийг түүнд өргөл болгон өгөгтүн, мөн мацаг барьж бас залбирахаа үргэлжлүүл, мөн эцсийг хүртэл тэвчигтүн; мөн Их Эзэн амьдардгийн адил та нар аврагдах болно.
- 27 Мөн эдүгээ би Нифайн нутагт буцахаар аглаг буйдад одсон хэдэн тооны хүмүүсийн талаар заримыг ярья; учир нь өвлөсөн нутгаа эзэмших хүсэлтэй нь олон байв.
- 28 Иймийн тул, тэд аглаг буйдад одсон юм. Мөн тэдний удирдагч хүчтэй бас чадалтай хүн, мөн зөрүүд нэгэн байлаа, иймийн тул тэрээр тэдний дунд маргаан үүсгэсэн ажгуу; мөн тэд аглаг буйдад тавиас бусад нь бүгд алагдаж, мөн тэд Зарахемлагийн нутагт, эргэж ирсэн бөлгөө.
- 29 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнчлэн нилээд олон тооны хүмүүнийг аваад, мөн дахин аглаг буйдад аянаа хөөв.

Behold, I, Amaleki, was born in the days of Mosiah; and I have lived to see his death; and Benjamin, his son, reigneth in his stead.

And behold, I have seen, in the days of king Benjamin, a serious war and much bloodshed between the Nephites and the Lamanites. But behold, the Nephites did obtain much advantage over them; yea, in-somuch that king Benjamin did drive them out of the land of Zarahemla.

And it came to pass that I began to be old; and, having no seed, and knowing king Benjamin to be a just man before the Lord, wherefore, I shall deliver up these plates unto him, exhorting all men to come unto God, the Holy One of Israel, and believe in prophesying, and in revelations, and in the ministering of angels, and in the gift of speaking with tongues, and in the gift of interpreting languages, and in all things which are good; for there is nothing which is good save it comes from the Lord: and that which is evil cometh from the devil.

And now, my beloved brethren, I would that ye should come unto Christ, who is the Holy One of Israel, and partake of his salvation, and the power of his redemption. Yea, come unto him, and offer your whole souls as an offering unto him, and continue in fasting and praying, and endure to the end; and as the Lord liveth ye will be saved.

And now I would speak somewhat concerning a certain number who went up into the wilderness to return to the land of Nephi; for there was a large number who were desirous to possess the land of their inheritance.

Wherefore, they went up into the wilderness. And their leader being a strong and mighty man, and a stiff-necked man, wherefore he caused a contention among them; and they were all slain, save fifty, in the wilderness, and they returned again to the land of Zarahemla.

And it came to pass that they also took others to a considerable number, and took their journey again into the wilderness.

30 Мөн Амаликай, би дүүтэй байлаа, түүнчлэн тэдэнтэй хамт явав; мөн түүнээс хойш тэдний талаар мэдсэнгүй билээ. Мөн би бараг доош булшиндаа хэвтэх минь дөхөж; мөн эдгээр ялтсууд дүүрчээ. Мөн би яриагаа төгсгөл болгоё.

And I, Amaleki, had a brother, who also went with them; and I have not since known concerning them. And I am about to lie down in my grave; and these plates are full. And I make an end of my speaking.

## МОРМОНЫ ҮГС

- 1 Мөн эдүгээ би, Мормон, хийсэн цэдгээ Моронай хүүгийнхээ гарт дамжуулан өгөх гэж байна, болгоогтун би өөрийн хүмүүс, нифайчуудын бараг л бүх устгалыг гэрчилсэн бөлгөө.
- 2 Мөн энэ нь Христийн ирэлтээс олон зуун жилийн дараа би эдгээр цэдгүүдийг хүүгийнхээ гарт дамжуулна; мөн тэрээр миний хүмүүсийн бүх устгалыг үзэх болно хэмээн надад санагдана. Гэвч тэрээр тэдгээрийн талаар зарим зүйлийг, мөн Христийн талаар зарим зүйлийг бичиж болно, хэзээ нэгэн өдөр энэ нь тэдний тусын төлөө байж болохын тулд Бурхан тэднийг гэтэлгэн амьд үлдэхийг зөвшөөрдөг ч болоосой.
- 3 Мөн эдүгээ, би бичиглэснийхээ талаар зарим зүйлийг ярь; учир нь би Нифайн ялтсуудаас Амаликайн ярьсан хаан Бенжаминь хаанчлалыг хүртэлх хураангуйллыг хийснийхээ дараа, гарт минь дамжуулагдсан уг цэдгүүдийн дунд би хайж, мөн Иаков энэхүү хаан Бенжаминь хаанчлалыг хүртэлх бошиглогчдын бага цэдгийг мөн түүнчлэн Нифайн олон үгсийг агуулсан эдгээр ялтсуудыг олсон бөлгөө.
- 4 Мөн эдгээр ялтсууд дээрх зүйлүүд нь Христийн ирэлтийн тухай бошиглолууд учир намайг баясгана; мөн миний эцэг өвгөд тэр болгон нь биелэгдсэнийг мэддэг бөлгөө; тийм ээ, энэ өдрийг хүртэлхийг тухайлан бидний талаар бошиглогдсон зүйлүүд болгон нь биелэгдсэнийг би түүнчлэн мэднэ, мөн энэ өдрөөс цааших нь гарцаагүй улиран тохиох ёстой—
- 5 Иймийн тул, би дээр нь өөрийн цэдгийг дуусгахаар эдгээр зүйлийг, Нифайн ялтсуудаас авах тэр үлдсэн хэсгийг сонгосон бөлгөө; мөн би өөрийн хүмүүсийн тухай зүйлүүдээс зууны нэг хэсгийг нь ч бичиж чадахгүй болой.
- 6 Гэвч болгоогтун, би эдгээр бошиглолууд мөн илчлэлтүүдийг агуулсан, эдгээр ялтсуудыг авах болно, мөн өөрийн цэдгийн үлдэгдэлтэй хамт тэдгээрийг хийнэ, учир нь тэдгээр нь надад сонгомол болой; мөн тэдгээр нь ах дүүсийн минь хувьд ч сонгомол байх болно гэдгийг би мэднэ.

## The Words of Mormon

And now I, Mormon, being about to deliver up the record which I have been making into the hands of my son Moroni, behold I have witnessed almost all the destruction of my people, the Nephites.

And it is many hundred years after the coming of Christ that I deliver these records into the hands of my son; and it supposeth me that he will witness the entire destruction of my people. But may God grant that he may survive them, that he may write somewhat concerning them, and somewhat concerning Christ, that perhaps some day it may profit them.

And now, I speak somewhat concerning that which I have written; for after I had made an abridgment from the plates of Nephi, down to the reign of this king Benjamin, of whom Amaleki spake, I searched among the records which had been delivered into my hands, and I found these plates, which contained this small account of the prophets, from Jacob down to the reign of this king Benjamin, and also many of the words of Nephi.

And the things which are upon these plates pleasing me, because of the prophecies of the coming of Christ; and my fathers knowing that many of them have been fulfilled; yea, and I also know that as many things as have been prophesied concerning us down to this day have been fulfilled, and as many as go beyond this day must surely come to pass—

Wherefore, I chose these things, to finish my record upon them, which remainder of my record I shall take from the plates of Nephi; and I cannot write the hundredth part of the things of my people.

But behold, I shall take these plates, which contain these prophesyings and revelations, and put them with the remainder of my record, for they are choice unto me; and I know they will be choice unto my brethren.

- 7 Мөн би үүнийг мэргэн зорилгын учир хийх бөлгөө; өөрөөр хэлбэл энэ нь, надад байх Их Эзэний Сүнсний нөлөөний дагуу надад ийн шивнэнэ. Мөн эдүгээ, би бүх зүйлийг мэдэхгүй; гэвч Их Эзэн ирэх бүх зүйлийг мэднэ; иймийн тул, тэрээр тааллынхаа дагуу надад оршин ажиллах буюу.
- 8 Мөн Бурханд хандсан залбирал минь миний ах дүүсийн талаар, тэд дахин нэгэнтээ Бурханы, тийм ээ, Христийн гэтэлгэлийн мэдлэгт орж болохын тулд буюу; тэд дахин нэгэнтээ бахдам сайхан хүмүүс байж болохын тулд буюу.
- 9 Мөн эдүгээ би, Мормон, Нифайн ялтсуудаас өөрийн авах тэрхүү цэдгийг дуусгахаар зорьё; мөн би үүнийг Бурхан надад өгсөн тэр мэдлэг хийгээд ойлголтын дагуу хийх болно.
- 10 Иймийн тул, улиран тохиох дор Амаликай эдгээр ялтсуудыг хаан Бенжамины гарт дамжуулан өгсний дараа, тэрээр тэдгээрийг авч мөн үеэс үед хаан Бенжамины өдрүүдийг хүртэл хаадаар дамжуулагдан ирсэн тэрхүү цэдгүүдийг агуулсан бусад ялтсуудтай хамт тавилаа.
- 11 Мөн хаан Бенжаминаас доош үеэс үед тэдгээр нь миний гарт ортлоо гардуулагдсан бөлгөө. Мөн би, Мормон, тэдгээр нь энэ цагаас хойшид ч хадгалагдан үлдэж болохын төлөө Бурханд залбирдаг. Мөн тэдгээр нь хамгаалагдах болно гэдгийг би мэднэ; учир нь тэдгээрийн дээр чухам түүнээс миний хүмүүс мөн тэдний ах дүүс агуу хийгээд эцсийн өдөр, бичигдсэн буй Бурханы үгийн дагуу шүүгдэх агуу зүйлүүд бичиглэгдсэн буй.
- 12 Мөн эдүгээ, энэ хаан Бенжамины талаар—түүний хүмүүсийн дунд зарим зөрчлүүд байв.
- 13 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг түүнчлэн түүний хүмүүсийн эсрэг байлдахаар Нифайн нутгаас уруудан ирэв. Гэвч болгоогтун, хаан Бенжамин их цэргээ нэгтгэн цуглуулж, мөн тэрээр тэдний эсрэг зогсов; бас тэрээр гарынхаа хүчээр, Лебений илдээр тулалдсан бөлгөө.
- 14 Мөн Их Эзэний хүчээр тэд дайснуудынхаа эсрэг, леменчүүдээс олон мянгыг устгах хүртэл тэмцэлдсэн билээ. Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн эсрэг тэднийг өвлөсөн бүх нутгаасаа хөөн гаргатлаа тэмцэлдсэн болой.

And I do this for a wise purpose; for thus it whispereth me, according to the workings of the Spirit of the Lord which is in me. And now, I do not know all things; but the Lord knoweth all things which are to come; wherefore, he worketh in me to do according to his will.

And my prayer to God is concerning my brethren, that they may once again come to the knowledge of God, yea, the redemption of Christ; that they may once again be a delightsome people.

And now I, Mormon, proceed to finish out my record, which I take from the plates of Nephi; and I make it according to the knowledge and the understanding which God has given me.

Wherefore, it came to pass that after Amaleki had delivered up these plates into the hands of king Benjamin, he took them and put them with the other plates, which contained records which had been handed down by the kings, from generation to generation until the days of king Benjamin.

And they were handed down from king Benjamin, from generation to generation until they have fallen into my hands. And I, Mormon, pray to God that they may be preserved from this time henceforth. And I know that they will be preserved; for there are great things written upon them, out of which my people and their brethren shall be judged at the great and last day, according to the word of God which is written.

And now, concerning this king Benjamin—he had somewhat of contentions among his own people.

And it came to pass also that the armies of the Lamanites came down out of the land of Nephi, to battle against his people. But behold, king Benjamin gathered together his armies, and he did stand against them; and he did fight with the strength of his own arm, with the sword of Laban.

And in the strength of the Lord they did contend against their enemies, until they had slain many thousands of the Lamanites. And it came to pass that they did contend against the Lamanites until they had driven them out of all the lands of their inheritance.

- 15 Мөнхүү улиран тохиох дор хуурамч Христүүд байв, мөн тэдний ам хамхигдаж, мөн тэд гэмт хэргүүдийнхээ дагуу шийтгэгдсэний дараа;
- 16 Мөн хуурамч бошиглогчид, мөн хуурамч номлогчид, бас багш нар хүмүүсийн дунд байв, мөн тэд бүгд гэмт хэргүүдийнхээ дагуу шийтгэгдсэний дараа; мөн олон маргаан болж мөн олон нь леменчүүдэд урваж одсоны дараа, болгоогтун, улиран тохиох дор хаан Бенжамин, түүний хүмүүсийн дунд байсан ариун бошиглогчдын тусламжтайгаар—
- 17 Учир нь болгоогтун, хаан Бенжамин ариун хүн байв, мөн тэрээр өөрийн хүмүүсийн дээр зөв шударгаар засаглаж байв; мөн уг нутагт ариун хүмүүс олон байлаа, мөн тэд Бурханы үгийг хүчтэйгээр мөн эрх мэдэлтэйгээр ярьдаг байв; мөн хүмүүсийн зөрүүдийн учир тэд ихэд хурцыг хэрэглэж байв—
- 18 Иймийн тул, тэдний тусламжтайгаар, хаан Бенжамин мөн түүнчлэн бошиглогчид маханбодийнхоо бүх хүч чадлаар мөн оюуныхаа бүх чадвараар хөдөлмөрлөснөөр, уг нутагт энх амгаланг дахин нэгэнтээ тогтоожээ.

And it came to pass that after there had been false Christs, and their mouths had been shut, and they punished according to their crimes;

And after there had been false prophets, and false preachers and teachers among the people, and all these having been punished according to their crimes; and after there having been much contention and many dissensions away unto the Lamanites, behold, it came to pass that king Benjamin, with the assistance of the holy prophets who were among his people—

For behold, king Benjamin was a holy man, and he did reign over his people in righteousness; and there were many holy men in the land, and they did speak the word of God with power and with authority; and they did use much sharpness because of the stiffneckedness of the people—

Wherefore, with the help of these, king Benjamin, by laboring with all the might of his body and the faculty of his whole soul, and also the prophets, did once more establish peace in the land.

# МОЗАЯГИЙН НОМ

## Мозая 1

- 1 Мөн эдүгээ Зарахемлагийн бүх нутагт, хаан Бенжаминд харъяалагдах бүх хүмүүсийн дунд дахин зөрчилдөөн огт байсангүй, иймээс хаан Бенжамин өөрийн үлдсэн бүх өдрийг үргэлжийн амгаланд өнгөрөөв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор түүнд гурван хүү байв; мөн тэрээр тэднийг Мозая, мөн Хилорум, Хиламан хэмээн нэрлэв. Мөн тэрээр тэд ойлголтыг агуулсан хүмүүс болж болохын тулд тэд эцэг өвгөдийнхөө бүх хэлэнд сургагдахаар болгов; мөн тэдний эцэг өвгөдийн амаар яригдсан, тэдэнд Их Эзэний мутраар өгөгдсөн бошиглолуудын талаар тэд мэдэж болно хэмээсний тул болой.
- 3 Мөн түүнчлэн тэрээр гуулин ялтсууд дээр сийлэгдсэн цэдгүүдийн талаар тэдэнд зааж, хэлсэн нь: Хөвгүүд минь, та нар эдгээр цэдгүүд мөн эдгээр зарлигуудыг тээсэн эдгээр ялтсууд байгаагүй аваас бид мэдэхгүйдээ зовох ёстой сон, бүр одоо цагт ч гэсэн, Бурханы нууцуудыг мэдэхгүй байсных гэдгийг та нарыг санаасай хэмээнэ би.
- 4 Учир нь эдгээр ялтсуудын тусламжгүй аваас бидний эцэг Лихай хүүхдүүддээ сургахын тулд эдгээр бүх зүйлийг цээжилж чадах нь боломжгүй байсан юм; учир нь тэрээр Египетийн хэлийг заалгасан байсан аж тиймийн тул тэрээр эдгээр сийлбэрүүдийг уншиж чадаад мөн тэдгээрийг хүүхдүүддээ заажээ, тэгээд тэд түүгээр нь хүүхдүүддээ зааж чадсан аж, мөн ингэснээр Бурханы зарлигуудыг, бүр одоо цагийг хүртэл биелүүсээр иржээ.
- 5 Би та нарт хэлнэ, хөвгүүд минь, бид түүний нууцуудыг уншиж мөн ойлгож болохын тулд, мөн түүний зарлигууд үргэлж бидний нүдний өмнө байж болохын тулд Бурханы мутраар хамгаалагдаж бас хадгалагдсан, эдгээр зүйлүүд байгаагүй аваас бүр бидний эцэг өвгөд итгэлгүйдээ доройтох бөлгөө, мөн бид эдгээр зүйлүүдийн талаар юу ч мэдэхгүй, эсвээс бүр эдгээрт үл итгэх тэр нь заагдсан байсан ч эцэг өвгөдийнхөө зөв бус уламжлалын учир өөрсдийн ах дүүс болох леменчүүдийн адил байх байсан биз ээ.

# The Book of Mosiah

## Mosiah 1

And now there was no more contention in all the land of Zarahemla, among all the people who belonged to king Benjamin, so that king Benjamin had continual peace all the remainder of his days.

And it came to pass that he had three sons; and he called their names Mosiah, and Helorum, and Helaman. And he caused that they should be taught in all the language of his fathers, that thereby they might become men of understanding; and that they might know concerning the prophecies which had been spoken by the mouths of their fathers, which were delivered them by the hand of the Lord.

And he also taught them concerning the records which were engraven on the plates of brass, saying: My sons, I would that ye should remember that were it not for these plates, which contain these records and these commandments, we must have suffered in ignorance, even at this present time, not knowing the mysteries of God.

For it were not possible that our father, Lehi, could have remembered all these things, to have taught them to his children, except it were for the help of these plates; for he having been taught in the language of the Egyptians therefore he could read these engravings, and teach them to his children, that thereby they could teach them to their children, and so fulfilling the commandments of God, even down to this present time.

I say unto you, my sons, were it not for these things, which have been kept and preserved by the hand of God, that we might read and understand of his mysteries, and have his commandments always before our eyes, that even our fathers would have dwindled in unbelief, and we should have been like unto our brethren, the Lamanites, who know nothing concerning these things, or even do not believe them when they are taught them, because of the traditions of their fathers, which are not correct.

- 6 Ай хөвгүүд минь, эдгээр хэллэгүүд үнэн, мөн түүнчлэн эдгээр цэдгүүд үнэн гэдгийг та нар санаасай хэмээнэ би. Мөн болгоогтун, түүнчлэн тэд Иерусалимыг орхисон тэр цагаас одоог хүртэл бидний эцэг өвгөдийн цэдгүүд мөн хэллэгүүдийг тээсэн, Нифайн ялтсууд, тэдгээр нь үнэн; мөн бид тэдгээрийн гарцаагүйг мэдэж чадахын учир нь тэдгээр нь бидний нүдний өмнө байна.
- 7 Мөн эдүгээ, хөвгүүд минь, та нар тэдгээрийг ашиглаж болохын тулд та нар тэдгээрийг хичээнгүйлэн судлахыг санаасай хэмээнэ би; мөн бидний эцэг өвгөдөд өгсөн Их Эзэний амлалтуудын дагуу та нар энэ нутагт дэгжихийн тулд, та нар Бурханы зарлигуудыг дагаасай хэмээнэ би.
- 8 Мөн хаан Бенжамин энэ номонд бичигдээгүй өөр олон зүйлийг хөвгүүддээ заасан ажээ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор хаан Бенжамин хөвгүүддээ сургахаа төгсгөл болгосны дараа, тэр өглөв, мөн тэрээр тун удахгүй бүх хорвоогийн жамаар одох ёстойгоо мэдсэн аж; тиймийн тул, тэр хаант улсыг хөвгүүдийнхээ нэгний нь мэдэлд шилжүүлэх нь зохистой хэмээн боджээ.
- 10 Тиймийн тул, тэрээр Мозаяг өөрийн өмнө авчруулав; мөн эдгээр нь түүнд хэлсэн түүний үгс бөлгөө, хэлрүүн: Хүү минь, та нар энэ бүх нутаг даяар бүх хүмүүсийн, өөрөөр хэлбэл уг нутагт орших Зарахемлагийн бүх хүмүүсийн, мөн Мозаягийн тэд цугларсан байж болохын тулд хүмүүсийн дунд зар бичиг тараагаасай хэмээнэ би; учир нь маргааш би өөрийн энэ хүмүүст өөрийн амаар чамайг Их Эзэн Бурханы минь бидэнд өгсөн хүмүүсийн удирдагч мөн хаан гэдгийг тунхаглах болно.
- 11 Мөн үүнээс гадна, тэд Их Эзэн Бурхан Иерусалим нутгаас гарган авчирсан бүх хүмүүсийн дээгүүр онцлогдож болохын тулд би энэ хүмүүст нэр өгөх болно; мөн тэд Их Эзэний зарлигуудыг дагахдаа хичээнгүй байсаар буй хүмүүс учир би үүнийг хийнэ.
- 12 Мөн зөрчилд байхаас бусдаар хэзээ ч арилгагдахгүй нэрийг би тэдэнд өгнө.

O my sons, I would that ye should remember that these sayings are true, and also that these records are true. And behold, also the plates of Nephi, which contain the records and the sayings of our fathers from the time they left Jerusalem until now, and they are true; and we can know of their surety because we have them before our eyes.

And now, my sons, I would that ye should remember to search them diligently, that ye may profit thereby; and I would that ye should keep the commandments of God, that ye may prosper in the land according to the promises which the Lord made unto our fathers.

And many more things did king Benjamin teach his sons, which are not written in this book.

And it came to pass that after king Benjamin had made an end of teaching his sons, that he waxed old, and he saw that he must very soon go the way of all the earth; therefore, he thought it expedient that he should confer the kingdom upon one of his sons.

Therefore, he had Mosiah brought before him; and these are the words which he spake unto him, saying: My son, I would that ye should make a proclamation throughout all this land among all this people, or the people of Zarahemla, and the people of Mosiah who dwell in the land, that thereby they may be gathered together; for on the morrow I shall proclaim unto this my people out of mine own mouth that thou art a king and a ruler over this people, whom the Lord our God hath given us.

And moreover, I shall give this people a name, that thereby they may be distinguished above all the people which the Lord God hath brought out of the land of Jerusalem; and this I do because they have been a diligent people in keeping the commandments of the Lord.

And I give unto them a name that never shall be blotted out, except it be through transgression.



13 Тийм ээ, мөн үүнээс гадна би чамд хэлнэ, хэрэв Их Эзэн ихээр таалсан энэ хүмүүс зөрчилд унах аваас, мөн ёс бус болон садар самуун хүмүүс болбоос, Их Эзэн тэднийг бусдын гарт оруулна, тэгснээр тэд өөрсдийн ах дүүс шиг сул дорой болох болно; мөн тэрээр тэднийг дахин өөрийн зүйрлэшгүй мөн гайхамшигт хүчээрээ бидний эцэг өвгөдийг одоо болтол хамгаалсан шигээ хамгаалах нь үгүй.

14 Учир нь би та нарт хэлнэ, хэрэв тэрээр мутраа бидний эцэг өвгөдийн өмгөөллийн төлөө сунгаагүй бол тэд леменчүүдийн гарт орж, мөн тэдний өс хонзонгийн золиос болох байсан нь гарцаагүй буйза.

15 Мөнхүү улиран тохиох дор хаан Бенжамин хүүдээ хандсан эдгээр үгсээ төгсгөл болгосны дараа, хаант улсын бүх хэргийн талаарх хариуцлагыг тэрээр түүнд өгөв.

16 Мөн үүнээс гадна, тэрээр түүнчлэн гуулин ялтсууд дээр сийлэгдсэн цэдгүүдийн талаарх хариуцлагыг; мөн түүнчлэн Нифайн ялтсуудыг; мөн түүнчлэн, Лебеней илдийг, мөн бидний эцэг өвгөдийг аглаг буйд дундуур удирдсан, түүгээр тэд хүн бүр түүнд хандуулсан анхаарал мөн хичээнгүйллийн дагуу удирдаж болохын тулд Их Эзэний мутраар бэлтгэгдсэн, тэрхүү бөмбөрцөг, өөрөөр хэлбэл тэр зүг чиг заагчийг түүнд өгөв.

17 Тиймийн тул, тэд итгэлгүйнхээ хэрээр дэгжиж бас аян замдаа урагшлах нь үгүй, харин буцаж туугдсан билээ, мөн Бурханы дургүйцлийг өөрсдийнхөө дээр авчирсан юм; мөн тиймийн тул тэд өлсгөлөн мөн зовлон зүдрэлүүдэд цохигдож, өөрсдийнх нь үүрэг сануулагдахын тулд тараагдсан бөлгөө.

18 Мөн эдүгээ, улиран тохиох дор Мозая явж мөн эцгийнхээ өөрт нь зарлигласныг хийж, мөн тэд эцгийнхээ өөрсдөд нь ярих үгсийг сонсохын тулд ариун сүм өөд явахаар нэгдэн цугларч болохын тулд Зарахемла нутагт байсан бүх хүмүүст тунхаглав.

Yea, and moreover I say unto you, that if this highly favored people of the Lord should fall into transgression, and become a wicked and an adulterous people, that the Lord will deliver them up, that thereby they become weak like unto their brethren; and he will no more preserve them by his matchless and marvelous power, as he has hitherto preserved our fathers.

For I say unto you, that if he had not extended his arm in the preservation of our fathers they must have fallen into the hands of the Lamanites, and become victims to their hatred.

And it came to pass that after king Benjamin had made an end of these sayings to his son, that he gave him charge concerning all the affairs of the kingdom.

And moreover, he also gave him charge concerning the records which were engraven on the plates of brass; and also the plates of Nephi; and also, the sword of Laban, and the ball or director, which led our fathers through the wilderness, which was prepared by the hand of the Lord that thereby they might be led, every one according to the heed and diligence which they gave unto him.

Therefore, as they were unfaithful they did not prosper nor progress in their journey, but were driven back, and incurred the displeasure of God upon them; and therefore they were smitten with famine and sore afflictions, to stir them up in remembrance of their duty.

And now, it came to pass that Mosiah went and did as his father had commanded him, and proclaimed unto all the people who were in the land of Zarahemla that thereby they might gather themselves together, to go up to the temple to hear the words which his father should speak unto them.

## Мозая 2

- 1 Мөнхүү улиран тохиох дор Мозая эцгийнхээ өөрт нь зарлиг болгосныг хийж, мөн бүх нутаг даяар зар бичгийг түгээсний дараа хаан Бенжамины тэдэнд ярих үгсийг сонсохоор тэд ариун сүм өөд очиж болохын тулд бүх нутаг даяар хүмүүс цугларав.
- 2 Мөн агуу олон тоотой, бүр тэд тэднийг тоолшгүй тийм олон байв; учир нь тэд үлэмж өнөржиж мөн уг нутагт агуу болсон бөлгөө.
- 3 Мөн тэд түүнчлэн сүргийнхээ ууган төлийг тэд Мосегийн хуулийн дагуу тахил өргөж, мөн өргөл хайлж болох хэмээн авчээ;
- 4 Мөн түүнчлэн тэд Иерусалим нутгаас тэднийг авчирсан, мөн тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлж, мөн Зарахемла нутагт амгаланг тогтоосон, мөн тэд баясаж мөн Бурханд болон бүх хүмүүст хандсан хайраар дүүргэгдэж болохын тулд Бурханы зарлигуудыг дагахыг тэдэнд сургасан шударга хүмүүнийг тэдний багш нар байхаар, мөн түүнчлэн шударга хүнийг тэдний хаан байхаар томилсон, өөрсдийн Бурхан, Их Эзэнд талархлаа илэрхийлж болохын тулд буюу.
- 5 Мөнхүү улиран тохиох дор тэд ариун сүм өөд ирээд, тэд майхнуудаа эргэн тойронд босгож, хүн бүр эхнэр, мөн хөвгүүдээ, мөн охидоо, мөн тэдний хөвгүүд, мөн тэдний охидоос бүрдсэн ахмадаас нь бага хүртэл, гэр бүлээрээ, гэр бүл болгон нэг нь нөгөөгөөсөө тусдаа байрлав.
- 6 Мөн тэд майхнуудаа ариун сүмийн эргэн тойронд босгож, хүн болгон майхныхаа амыг ариун сүмийг чиглүүлэв, тэгснээр тэд майхнууддаа үлдэн мөн хаан Бенжамины тэдэнд ярих үгсийг сонсож байв.
- 7 Учир нь олон түмэн маш их байсны учир хаан Бенжамин тэд бүгдэд ариун сүмийн ханан дотор багтаан зааж чадсангүй, тиймийн тул хүмүүс түүний тэдэнд ярих тэр үгсийг сонсож болохын тулд тэрээр цамхаг босгуулав.

## Mosiah 2

And it came to pass that after Mosiah had done as his father had commanded him, and had made a proclamation throughout all the land, that the people gathered themselves together throughout all the land, that they might go up to the temple to hear the words which king Benjamin should speak unto them.

And there were a great number, even so many that they did not number them; for they had multiplied exceedingly and waxed great in the land.

And they also took of the firstlings of their flocks, that they might offer sacrifice and burnt offerings according to the law of Moses;

And also that they might give thanks to the Lord their God, who had brought them out of the land of Jerusalem, and who had delivered them out of the hands of their enemies, and had appointed just men to be their teachers, and also a just man to be their king, who had established peace in the land of Zarahemla, and who had taught them to keep the commandments of God, that they might rejoice and be filled with love towards God and all men.

And it came to pass that when they came up to the temple, they pitched their tents round about, every man according to his family, consisting of his wife, and his sons, and his daughters, and their sons, and their daughters, from the eldest down to the youngest, every family being separate one from another.

And they pitched their tents round about the temple, every man having his tent with the door thereof towards the temple, that thereby they might remain in their tents and hear the words which king Benjamin should speak unto them;

For the multitude being so great that king Benjamin could not teach them all within the walls of the temple, therefore he caused a tower to be erected, that thereby his people might hear the words which he should speak unto them.

- 8 Мөнхүү улиран тохиох дор тэрээр өөрийн хүмүүст цамхгаас ярьж эхлэв; мөн тэд бүгд түүний үгсийг сонсож чадсангүйн учир нь хүний олноос бөлгөө; тиймийн тул тэрээр өөрийн ярьсан үгсийг бичүүлж мөн түүний дуу хүрэхгүй газар байгаа тэд түүнчлэн үгсийг нь хүлээн авч болохын тулд тэдний дунд илгээлгэв.
- 9 Мөн эдгээр нь түүний ярьсан мөн бичүүлсэн үгс буюу, хэлсэн нь: Ах дүүс минь, энэ өдөр та нарт миний ярих үгсийг сонсож болохын тулд, та бүгд өөрсдөө чуулжээ; өөрөөр хэлбэл та нарыг нааш ирж миний ярих үгсийг тохуурхахыг би зарлиг болгоогүй, харин та нар намайг анхааран сонсогтун, мөн та нар сонсож болохын тулд сонороо дэлгэгтүн, мөн ойлгож болохын тул зүрх сэтгэлээ нээгтүн, мөн та нарын төсөөлөлд Бурханы нууцууд дэлгэгдэж болохын тулд оюунаа нээгтүн.
- 10 Би та нарыг надаас айх ёстой хэмээн, эсвээс та нар намайг зуурдын хүнээс илүү гэж бодох ёстой учир нааш ирэхийг зарлиг болгосонгүй.
- 11 Харин би та нарын адил, биед мөн оюунд байх янз бүрийн мөн сул дорой байдлын харъяат болой; гэвч би энэ хүмүүсээр сонгогдож, мөн эцгээрээ адислагдан томилогдсон билээ, мөн энэ хүмүүсийн дээр хаан хийгээд захирагч байхын тулд Их Эзэний мутраар зөвшөөрөгдсөн буюу; мөн Их Эзэн надад хайрласан бүхий л хүч, оюун мөн чадлаараа та бүхэнд үйлчлэхээр түүний зүйрлэшгүй хүчээр хадгалагдаж мөн хамгаалагдсаар буй.
- 12 Би та нарт хэлье, өөрийн өдрүүдэд та нарт үйлчлэхээр зөвшөөрөгдөн, бүр энэ цагийг хүртэл, мөн та нараас алт бас мөнгө ч, мөн ямар ч баялгуудыг эрэлхийлээгүй болой;
- 13 Мөн та нар гянданд хоригдохыг, мөн та нар нэг нэгнээ боол болгохыг, мөн та нар аллага, эсвээс дээрэм буюу хулгай хийхийг, эсвээс садар самууныг үйлдэхийг би зөвшөөрөөгүй; бүр та нарыг ямар нэгэн байдлаар ёс бусыг үйлдэхийг би зөвшөөрөөгүй, мөн та нарт түүний зарлиг болсон бүх зүйлд Их Эзэний зарлигуудыг та нар дагах ёстой хэмээн та нарт заасан бөлгөө—

And it came to pass that he began to speak to his people from the tower; and they could not all hear his words because of the greatness of the multitude; therefore he caused that the words which he spake should be written and sent forth among those that were not under the sound of his voice, that they might also receive his words.

And these are the words which he spake and caused to be written, saying: My brethren, all ye that have assembled yourselves together, you that can hear my words which I shall speak unto you this day; for I have not commanded you to come up hither to trifle with the words which I shall speak, but that you should hearken unto me, and open your ears that ye may hear, and your hearts that ye may understand, and your minds that the mysteries of God may be unfolded to your view.

I have not commanded you to come up hither that ye should fear me, or that ye should think that I of myself am more than a mortal man.

But I am like as yourselves, subject to all manner of infirmities in body and mind; yet I have been chosen by this people, and consecrated by my father, and was suffered by the hand of the Lord that I should be a ruler and a king over this people; and have been kept and preserved by his matchless power, to serve you with all the might, mind and strength which the Lord hath granted unto me.

I say unto you that as I have been suffered to spend my days in your service, even up to this time, and have not sought gold nor silver nor any manner of riches of you;

Neither have I suffered that ye should be confined in dungeons, nor that ye should make slaves one of another, nor that ye should murder, or plunder, or steal, or commit adultery; nor even have I suffered that ye should commit any manner of wickedness, and have taught you that ye should keep the commandments of the Lord, in all things which he hath commanded you—

14 Мөн би бүр, өөрөө, та нарт би үйлчилж болохын тулд, мөн та нар татваруудад дарагдахгүй байхын тулд, мөн үүрэхэд хүнд юухан ч та нарын дээр үгүй байхын тулд өөрийн гараар хөдөлмөрлөсөн—мөн миний ярьсан эдгээр бүх зүйлийн гэрчлэгч нь та нар өөрсдөө шүү дээ.

15 Гэвч, ах дүүс минь, би эдгээр зүйлийг бардамнан сайрхаж болохын тулд хийсэн бус, бас би эдгээр зүйлийг түүгээр би та нарыг зэмлэхийн тулд хэлж буй бус; харин энэ өдөр Бурханы өмнө би цэвэр ухамсартайгаар хариулж чадахыг минь та нар мэдэж болохын тулд би эдгээр зүйлийг та нарт хэллээ.

16 Болгоогтун, би та нарт хэлнэ, би та нарт өөрийн өдрүүдийг та нарт үйлчлэхэд зориулсан гэж би хэлсний учир, би бардамнан сайрхахыг хүсэх минь үгүй, учир нь би зөвхөн Бурханд үйлчилж байсан бөлгөө.

17 Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлийг та нар мэргэн ухааныг сурч болохын тулд хэллээ; та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу.

18 Болгоогтун, та нар намайг хаанаа болгосон; мөн хэрэв би та нарын хаан болгосон тэрбээр, та нарт үйлчлэхээр хөдөлмөрлөх аваас та нар нэг нэгэндээ үйлчлэхээр хөдөлмөрлөх ёстой бус уу

19 Мөн түүнчлэн болгоогтун, хэрэв би, та нарын хаанаа болгосон тэрбээр, өөрийн өдрүүдээ та нарын үйлчлэлд зориулсан тэрбээр, мөн Бурханы үйлчлэлд байсан аваас, та нарын талархлыг хүлээх нь зохистой юм бол, Ай та нар тэнгэрлэг Хаандаа талархах нь хичнээн их зохистой билээ!

20 Би та нарт хэлнэ, ах дүүс минь, хэрэв та нар бүхэл бодгальд чинь агуулагдаж болох бүх талархал мөн магтаалыг илгээсэн ч, та нарыг бүтээсэн, мөн та нарыг хадгалж үлдсэн бас хамгаалсан, мөн та нарыг баясгаж, мөн та нарыг нэг нэгтэйгээ амар амгаланд амьдрахыг зөвшөөрсөн тэрхүү Бурханд буюу—

And even I, myself, have labored with mine own hands that I might serve you, and that ye should not be laden with taxes, and that there should nothing come upon you which was grievous to be borne—and of all these things which I have spoken, ye yourselves are witnesses this day.

Yet, my brethren, I have not done these things that I might boast, neither do I tell these things that thereby I might accuse you; but I tell you these things that ye may know that I can answer a clear conscience before God this day.

Behold, I say unto you that because I said unto you that I had spent my days in your service, I do not desire to boast, for I have only been in the service of God.

And behold, I tell you these things that ye may learn wisdom; that ye may learn that when ye are in the service of your fellow beings ye are only in the service of your God.

Behold, ye have called me your king; and if I, whom ye call your king, do labor to serve you, then ought not ye to labor to serve one another?

And behold also, if I, whom ye call your king, who has spent his days in your service, and yet has been in the service of God, do merit any thanks from you, O how you ought to thank your heavenly King!

I say unto you, my brethren, that if you should render all the thanks and praise which your whole soul has power to possess, to that God who has created you, and has kept and preserved you, and has caused that ye should rejoice, and has granted that ye should live in peace one with another—

21 Би та нарт хэлье, хэрэв та нар эхлэлээс та нарыг бүтээсэн түүнд, мөн та нарыг өдрөөс өдөрт хадгалан хамгаалж буй, танд амьсгалыг өгснөөр, та өөрийн хүслээр амьдарч мөн хөдөлж мөн хийж болохын тулд, мөн бүр таныг нэг хормоос нөгөөд дэмжих түүнд үйлчилсэн ч—би хэлнэ, хэрэв та нар түүнд өөрсдийн бүхий л бие сэтгэлээрээ үйлчилсэн ч, та нар ашиггүй зарц нар хэвээр байх бөлгөө.

22 Мөн болгоогтун, та нараас түүний хүсдэг бүхэн нь түүний зарлигуудыг дагах юм; мөн хэрэв та нар түүний зарлигуудыг дагавал та нар уг нугагт дэгжих болно хэмээн тэрээр та нарт амласан бөлгөө; мөн тэрээр хэлснээсээ хэзээ ч ухардаггүй; тиймийн тул, хэрэв та нар түүний зарлигуудыг дагавал тэр та нарыг адисалж мөн та нарыг дэгжээх бөлгөө.

23 Мөн эдүгээ, юун түүрүүнд, тэр та нарыг бүтээсэн, мөн та нарт амьдралыг тань хайрласан, үүний улмаас та нар түүнд өртэй болой.

24 Мөн хоёрдугаарт, тэр та нарт өөрийнхөө зарлигласныг хийхийг та нараас шаарддаг; хэрэв та нар үүнийг хийвэл оронд нь, тэрээр та нарыг тэр даруй адисалдаг; мөн тиймийн тул тэрбээр та нарт төлсөн байдаг. Мөн та нар түүнд өртэй хэвээр, мөн тийм байгаа, мөн тийм байх болно, үүрд мөн үргэлж; тиймийн тул, та нар юугаар бардамнах билээ

25 Мөн эдүгээ би асууя, та нар өөрсдийгөө юухан ч биш гэж хэлж чадах уу? Би та нарт хариулья, Үгүй. Та нар бүр энэ газрын тоосны төдий гэж ч хэлж чадахгүй; гэсэн хэдий ч та нар энэ газрын тоосноос бүтээгдсэн; гэвч болгоогтун, энэ нь та нарыг бүтээсэн түүнд хамаарагддаг шүү дээ.

26 Мөн би, бүр би, та нар хаан хэмээн хүндэлдэг тэрбээр, би та нараас өөрсдөөс тань илүүгүй билээ; учир нь би ч түүнчлэн тоосноос буюу. Мөн миний нас өтөл гэдгийг, мөн би энэ зуурдын биеийг өөрийнх нь газар эхэд тушаахад ойрхон байгааг та нар болгоох биз ээ.

27 Тиймийн тул, та нарт би хэлсэнчлэн би та нарт үйлчилж Бурханы өмнө цэвэр ухамсартайгаар алхсан, бүр энэ удаа ч гэсэн та нарыг энд цуглуулсан нь тэрээр надад та нарын талаар зарлигласан зүйлүүдийн дагуу Бурханаар шүүгдэхээр намайг зогсоход миний буруугүй нь тогтоогдож, мөн та нарын цус над дээр ирэхгүйн тулд болой.

I say unto you that if ye should serve him who has created you from the beginning, and is preserving you from day to day, by lending you breath, that ye may live and move and do according to your own will, and even supporting you from one moment to another—I say, if ye should serve him with all your whole souls yet ye would be unprofitable servants.

And behold, all that he requires of you is to keep his commandments; and he has promised you that if ye would keep his commandments ye should prosper in the land; and he never doth vary from that which he hath said; therefore, if ye do keep his commandments he doth bless you and prosper you.

And now, in the first place, he hath created you, and granted unto you your lives, for which ye are indebted unto him.

And secondly, he doth require that ye should do as he hath commanded you; for which if ye do, he doth immediately bless you; and therefore he hath paid you. And ye are still indebted unto him, and are, and will be, forever and ever; therefore, of what have ye to boast?

And now I ask, can ye say aught of yourselves? I answer you, Nay. Ye cannot say that ye are even as much as the dust of the earth; yet ye were created of the dust of the earth; but behold, it belongeth to him who created you.

And I, even I, whom ye call your king, am no better than ye yourselves are; for I am also of the dust. And ye behold that I am old, and am about to yield up this mortal frame to its mother earth.

Therefore, as I said unto you that I had served you, walking with a clear conscience before God, even so I at this time have caused that ye should assemble yourselves together, that I might be found blameless, and that your blood should not come upon me, when I shall stand to be judged of God of the things whereof he hath commanded me concerning you.

28 Би та нарыг өөрсдөө нэгдэн чуулах болгосон нь би өмсгөлөө та нарын цуснаас ангижруулж болохын тулд, бараг булшиндаа доош орох болсон энэ цаг үед, би тайван доош одож болохын тулд, мөн миний үхэшгүй сүнс шударга Бурханы магтаалыг дуулахад эрхэм дээдэд буй найрал дуунд нэгдэж болохын тулд гэдгийг би та нарт хэлнэ.

29 Мөн үүнээс гадна, би та нарт үүнээс хойш та нарын багш, бас танай хаан ч байж чадахгүйг мэдэгдэж болохын тулд, би та нарыг чуулах болгосоныг би та нарт хэлнэ;

30 Учир нь бүр энэ цагт ч, та нарт ярихаар оролдож байх зуур миний бүх бие үлэмж салгалан байна; гэвч Их Эзэн Бурхан намайг дэмждэг, мөн намайг та нарт яривал зохино хэмээн зөвшөөрсөн, мөн энэ өдөр миний хүү Мозая та нарын дээрх хаан мөн захирагч гэдгийг та нарт мэдэгдвэл зохино хэмээн надад зарлигласан бөлгөө.

31 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нарыг одоог хүртэл үйлдсэн шигээ хийгээсэй хэмээнэ би. Та нар миний зарлигуудыг дагасан, мөн түүнчлэн эцгийн минь зарлигуудыг дагаж, мөн дэгжсэн, мөн дайснуудынхаа гарт оролгүй хамгаалагдсан шиг, үүнчлэн хэрэв та нар хүүгийн минь зарлигуудыг, өөрөөр хэлбэл түүгээр та нарт өгөгдөх Бурханы зарлигуудыг дагах аваас, та нар уг нутагт дэгжиж, мөн дайснууд чинь та нарыг дийлэх хүчгүй байх болно.

32 Гэвч, Ай хүмүүс минь, та нарын дунд зөрчлүүд байхаас, мөн миний эцэг Мозаягаар яригдсан тэр ёс бусын сүнсийг та нар дагахаар хэлбийхээс айж болгоомжил.

33 Учир нь болгоогтун, тэр сүнсийг дагахаар сонгосон түүний дээр халаг зарлагдсан; учир нь хэрэв тэрээр түүнийг дагахаар сонгож мөн нүглүүддээ үлдэж мөн үхвээс, түүнчлэн тэрбээр өөрийн бодгальд ял уулгах болой; учир нь тэрээр өөртөө хөлс болгон үүрдийн шийтгэлийг хүлээн авна, тэрээр өөрийн мэдлэгийн эсрэг Бурханы хуулийг зөрчсөн буюу.

I say unto you that I have caused that ye should assemble yourselves together that I might rid my garments of your blood, at this period of time when I am about to go down to my grave, that I might go down in peace, and my immortal spirit may join the choirs above in singing the praises of a just God.

And moreover, I say unto you that I have caused that ye should assemble yourselves together, that I might declare unto you that I can no longer be your teacher, nor your king;

For even at this time, my whole frame doth tremble exceedingly while attempting to speak unto you; but the Lord God doth support me, and hath suffered me that I should speak unto you, and hath commanded me that I should declare unto you this day, that my son Mosiah is a king and a ruler over you.

And now, my brethren, I would that ye should do as ye have hitherto done. As ye have kept my commandments, and also the commandments of my father, and have prospered, and have been kept from falling into the hands of your enemies, even so if ye shall keep the commandments of my son, or the commandments of God which shall be delivered unto you by him, ye shall prosper in the land, and your enemies shall have no power over you.

But, O my people, beware lest there shall arise contentions among you, and ye list to obey the evil spirit, which was spoken of by my father Mosiah.

For behold, there is a wo pronounced upon him who listeth to obey that spirit; for if he listeth to obey him, and remaineth and dieth in his sins, the same drinketh damnation to his own soul; for he receiveth for his wages an everlasting punishment, having transgressed the law of God contrary to his own knowledge.

34 Би та нарт хэлнэ, бяцхан хүүхдүүдээс гадна та нарын дунд энэ зүйлүүдийн талаар заалгаагүй, өөрт байгаа бүхнээ мөн өөрийгөө бүхлээр нь Тэнгэрлэг Эцэгтээ өгөх мөнхийн өрөнд орсон гэдгийг мэдэхгүй; мөн түүнчлэн бүр бидний эцэг Лихай Иерусалимыг орхисон тэр цагийг хүртэл ариун бошиглогчдоор яригдсаар байсан уг бошиглолуудыг тээсэн цэдгүүдийн талаар заалгаагүй хүн байхгүй;

35 Мөн түүнчлэн, одоог хүртэл бидний эцэг өвгөдөөр яригдсаар байгаа бүгдийг тээх тэдгээрийн талаар буюу. Мөн болгоогтун, түүнчлэн, Их Эзэний тэдэнд зарлигласан түүнийг тэд ярьсан бөлгөө; тиймийн тул, тэдгээр нь шударга бас үнэн болой.

36 Мөн эдүгээ, би та нарт хэлнэ, ах дүүс минь, та нар эдгээр бүх зүйлийг заалгасан мөн мэдсэнийхээ дараа, хэрэв та нар зөрчил гаргаж мөн яригдсаар байгаа түүний эсрэг явбаас та нар өөрсдийгөө Их Эзэний Сүнснээс холдуулна, ингэснээр та нар адислагдсан, дэгжсэн, мөн хадгалагдан үлдсэн байж болохын тулд тэрхүү мэргэн ухааны замд та нарыг удирдахад үүний орших зай та нарт байж чадахгүй биз ээ—

37 Би та нарт хэлнэ, үүнийг үйлдсэн хүмүүн, мөнхүү тэр нь Бурханы эсрэг илэрхий тэмцлээр гарч ирэх буюу; тиймийн тул, тэр ёс бусын сүнсийг дагахаар сонгож, мөн бүх шударга ёсны дайсан болно; тиймийн тул, Их Эзэнд түүний дотор байр үгүй, учир нь тэрээр ариун бус дуганд үл орших бөлгөө.

38 Тиймийн тул хэрэв тэр хүмүүн эс наманчилбаас, мөн Бурханы дайсан хэвээр үлдэн мөн үхвээс, тэнгэрлэг шударга ёсны шаардлага түүний үхэшгүй сүнсийг өөрийнх нь гэрийн амьд мэдрэмжинд сэрээж, түүнийг Их Эзэний дэргэдээс зайлсхийх болгосон тэр, мөн түүний цээжийг гэм, шаналал хийгээд тарчлалаар дүүргэх бөлгөө, түүнчлэн дөл нь үүрд мөн үргэлж дүрэлзэх тэр, унтаршгүй гал лугаа адил байх тэр бөлгөө.

39 Мөн эдүгээ би та нарт хэлье, тэр хүмүүн дээр нигүүлсэл байх эрхгүй; тиймийн тул түүний эцсийн ял нь хэзээ ч төгсөшгүй үргэлжлэх тарчлалыг амсах тэрбээр болой.

I say unto you, that there are not any among you, except it be your little children that have not been taught concerning these things, but what knoweth that ye are eternally indebted to your heavenly Father, to render to him all that you have and are; and also have been taught concerning the records which contain the prophecies which have been spoken by the holy prophets, even down to the time our father, Lehi, left Jerusalem;

And also, all that has been spoken by our fathers until now. And behold, also, they spake that which was commanded them of the Lord; therefore, they are just and true.

And now, I say unto you, my brethren, that after ye have known and have been taught all these things, if ye should transgress and go contrary to that which has been spoken, that ye do withdraw yourselves from the Spirit of the Lord, that it may have no place in you to guide you in wisdom's paths that ye may be blessed, prospered, and preserved—

I say unto you, that the man that doeth this, the same cometh out in open rebellion against God; therefore he listeth to obey the evil spirit, and becometh an enemy to all righteousness; therefore, the Lord has no place in him, for he dwelleth not in unholy temples.

Therefore if that man repenteth not, and remaineth and dieth an enemy to God, the demands of divine justice do awaken his immortal soul to a lively sense of his own guilt, which doth cause him to shrink from the presence of the Lord, and doth fill his breast with guilt, and pain, and anguish, which is like an unquenchable fire, whose flame ascendeth up forever and ever.

And now I say unto you, that mercy hath no claim on that man; therefore his final doom is to endure a never-ending torment.

40 Ай, настай эрчүүд та нар, мөн түүнчлэн залуу эрчүүд та нар, мөн миний үгсийг ойлгож чадах бяцхан хүүхдүүд та нар, учир нь та нар ойлгож болохын тулд би та нарт тодорхой ярьсан, зөрчилд унасан тэдний аймшигт байдлыг санахаар та нарыг сэрээсэй хэмээн залбирнам би.

41 Мөн үүнээс гадна, Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай хэмээн хүснэ би. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлд, биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан болой; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвчвээс, тэгвэл тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэд тэнгэрт хүлээн авагдах болно. Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэнийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан юм.

O, all ye old men, and also ye young men, and you little children who can understand my words, for I have spoken plainly unto you that ye might understand, I pray that ye should awake to a remembrance of the awful situation of those that have fallen into transgression.

And moreover, I would desire that ye should consider on the blessed and happy state of those that keep the commandments of God. For behold, they are blessed in all things, both temporal and spiritual; and if they hold out faithful to the end they are received into heaven, that thereby they may dwell with God in a state of never-ending happiness. O remember, remember that these things are true; for the Lord God hath spoken it.



## Мозая 3

- 1 Мөн түүнчлэн ах дүүс минь, би та нарын анхаарлыг хандуулъя, учир нь та нарт ярих өөр зарим зүйл надад байна; учир нь болгоогтун, ирэх түүний талаар та нарт хэлэх зүйлүүд надад байна.
- 2 Мөн та нарт миний хэлэх зүйлүүд Бурханы тэнгэр элчээр надад мэдүүлэгдсэн билээ. Мөн тэрээр надад: Сэрэгтүн хэмээв; мөн би сэрсэн, мөн болгоогтун тэрбээр миний өмнө зогсов.
- 3 Мөн тэрээр надад хэлэв: Сэрэгтүн, тэгээд танд миний хэлэх үгсийг сонс; учир нь болгоогтун, би чамд агуу их баясгалангийн баярт мэдээг зарлахаар ирлээ.
- 4 Учир нь Их Эзэн таны залбирлуудыг анхааран сонссон, мөн зөв шударга тань шүүгдэн тунгаагдсан билээ, мөн та баясаж болно; мөн тэд түүнчлэн баяслаар дүүргэгдэж болохын тулд та өөрийн хүмүүст зарлаж болно хэмээн танд зарлан мэдүүлэхээр намайг танд илгээсэн бөлгөө.
- 5 Учир нь болгоогтун, тэр цаг ирнэ, мөн энэ нь хол зайтай бус, засаглах тэр, байсан, мөн үүрд мөнхөөс үүрд мөнхөд байдаг тэр, Төгс Хүчит Их Эзэн хүмүүний үрсийн дунд тэнгэрээс хүчтэйгээр бууж ирэх болно, мөн махбодийн асарт орших болно, мөн өвчтөнийг эдгээж, үхсэнийг босгон, хазгарыг алхуулж, сохрыг хараатай болгож, мөн дүлийг сонсгож, мөн зүйл бүрийн эмгэгийг анагаах зэрэг хүчит гайхамшгуудыг үйлдэн, хүмүүний дунд урагшлан явах болно.
- 6 Мөн тэрээр хүмүүний үрсийн зүрх сэтгэлд орших ёс бусын сүнснүүд, өөрөөр хэлбэл чөтгөрүүдийг зайлуулах болно.
- 7 Мөн үз, тэрээр уруу таталтыг, мөн биесийн өвчин, өлсгөлөн, цангаа, мөн зүдрэлийг, энэ нь үхэлд хүргэхээс бусдаар бол, бүр хүмүүний тэвчиж чадахаас илүүг тэвчих болно; учир нь болгоогтун, арьсных нь сүв бүрээс цус шүүрэх болно, өөрийнхөө хүмүүсийн ёс бус мөн жигшүүрт хэргүүдийн төлөөх түүний тарчлал ийм агуу байх болно.
- 8 Мөн тэрээр Есүс Христ, Бурханы Хүү, тэнгэр ба газрын Эцэг, эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч хэмээн нэрлэгдэх болно; мөн түүний эх Мариа гэгдэх болно.

## Mosiah 3

And again my brethren, I would call your attention, for I have somewhat more to speak unto you; for behold, I have things to tell you concerning that which is to come.

And the things which I shall tell you are made known unto me by an angel from God. And he said unto me: Awake; and I awoke, and behold he stood before me.

And he said unto me: Awake, and hear the words which I shall tell thee; for behold, I am come to declare unto you the glad tidings of great joy.

For the Lord hath heard thy prayers, and hath judged of thy righteousness, and hath sent me to declare unto thee that thou mayest rejoice; and that thou mayest declare unto thy people, that they may also be filled with joy.

For behold, the time cometh, and is not far distant, that with power, the Lord Omnipotent who reigneth, who was, and is from all eternity to all eternity, shall come down from heaven among the children of men, and shall dwell in a tabernacle of clay, and shall go forth amongst men, working mighty miracles, such as healing the sick, raising the dead, causing the lame to walk, the blind to receive their sight, and the deaf to hear, and curing all manner of diseases.

And he shall cast out devils, or the evil spirits which dwell in the hearts of the children of men.

And lo, he shall suffer temptations, and pain of body, hunger, thirst, and fatigue, even more than man can suffer, except it be unto death; for behold, blood cometh from every pore, so great shall be his anguish for the wickedness and the abominations of his people.

And he shall be called Jesus Christ, the Son of God, the Father of heaven and earth, the Creator of all things from the beginning; and his mother shall be called Mary.

- 9 Мөн үз, тэрээр өөрийнхөндөө ирнэ, аврал нь мөн түүний нэрэнд итгэх итгэлээр хүмүүний үрсэд ирж болохын тулд буюу; мөн бүр энэ бүгдийн дараа ч тэд түүнийг хүн хэмээн бодож, мөн түүнд чөтгөр шүглэсэн хэмээн хэлж, мөн түүнийг ташуурдаж, мөн түүнийг цовдлох болно.
- 10 Мөн тэр гурав дахь өдөр нь нас барагсдаас босох болно; мөн болгоогтун, тэрээр дэлхийг шүүхээр зогсоно; мөн болгоогтун, хүмүүний үрсийн дээр зөв шударга шүүлт ирж болохын тулд эдгээр бүх зүйл үйлдэгдэх болно.
- 11 Учир нь болгоогтун, мөн түүнчлэн түүний цус, Адамын зөрчлөөр унагагдсан тэд, өөрсдийн талаарх Бурханы тааллыг мэдэлгүйгээр нас барсан тэд, өөрөөр хэлбэл үл мэдэн нүгэл үйлдсэн тэдний нүглүүдийг цагаатгах болно.
- 12 Гэвч Бурханы эсрэг тэмцэж буйгаа мэдэх түүнд халаг, халаг! Учир нь наманчлал мөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжихаас бусдаар бол эдний хэний нь ч дээр аврал ирэх нь үгүй.
- 13 Мөн түүгээр хэн боловч Христ ирэх ёстой гэдэгт итгэж, мөнхүү тэд нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч, мөн бүр тэрээр аль хэдийн тэдний дунд ирсэн мэт тийм үлэмж агуу баяслаар баярлаж болохын тул эдгээр зүйлийг үндэстэн, ястан, мөн хэлтэн бүрд зарлуулахаар Их Эзэн Бурхан ариун бошиглогчдоо хүмүүний үрсийн дунд илгээсэн бөлгөө.
- 14 Гэвч Их Эзэн Бурхан түүний хүмүүс хөшүүн хүзүүтэй хүмүүс байсныг харсан, мөн тэрээр тэдний дээр нэгэн хуулийг, бүр Мосегийн хуулийг тогтоосон билээ.
- 15 Мөн олон тэмдэг, мөн гайхамшгууд, мөн бэлэгдлүүд, мөн дүрслэлүүдийг тэрээр тэдэнд үзүүлсэн, өөрийн ирэлтийн талаар буюу; мөн түүнчлэн ариун бошиглогчид түүний ирэлтийн талаар тэдэнд ярьсан бөлгөө; тийм хэдий ч тэд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн Мосегийн хууль түүний цусны цагаатгалаар бус аваас огтхон ч тус болохгүйг ойлгосонгүй.

And lo, he cometh unto his own, that salvation might come unto the children of men even through faith on his name; and even after all this they shall consider him a man, and say that he hath a devil, and shall scourge him, and shall crucify him.

And he shall rise the third day from the dead; and behold, he standeth to judge the world; and behold, all these things are done that a righteous judgment might come upon the children of men.

For behold, and also his blood atoneth for the sins of those who have fallen by the transgression of Adam, who have died not knowing the will of God concerning them, or who have ignorantly sinned.

But wo, wo unto him who knoweth that he rebelleth against God! For salvation cometh to none such except it be through repentance and faith on the Lord Jesus Christ.

And the Lord God hath sent his holy prophets among all the children of men, to declare these things to every kindred, nation, and tongue, that thereby whosoever should believe that Christ should come, the same might receive remission of their sins, and rejoice with exceedingly great joy, even as though he had already come among them.

Yet the Lord God saw that his people were a stiff-necked people, and he appointed unto them a law, even the law of Moses.

And many signs, and wonders, and types, and shadows showed he unto them, concerning his coming; and also holy prophets spake unto them concerning his coming; and yet they hardened their hearts, and understood not that the law of Moses availeth nothing except it were through the atonement of his blood.

- 16 Мөн бяцхан хүүхдүүд нүгэл үйлдэх боломжтой байсан бол, тэд аврагдаж чадахгүй байхсан; гэвч тэд адислагдсаныг би та нарт хэлье; учир нь болгоогтун, Адамаар, өөрөөр хэлбэл төрөлх чанараараа, тэд унасан шиг, тэрчлэн Христийн цус тэдний нүглүүдийг цагаатгасан бөлгөө.
- 17 Мөн үүнээс гадна, би та нарт хэлнэ, түүгээр хүмүүний үрсэд аврал ирж чадах тэр нэгээхэн ч өөр нэр өгөгдөхгүй, басхүү нэгээхэн ч өөр зам, мөн нэгээхэн ч арга үгүй бөгөөд зөвхөн Төгс Хүчит Их Эзэн, Христийн нэрээр мөн энэ нэр дээр буюу.
- 18 Учир нь болгоогтун тэрээр шүүнэ, мөн түүний шүүлт шударга; мөн нялхдаа нас барах тэрхүү нялхас мөхөхгүй; гэвч тэд өөрсдийгөө даруусган мөн бяцхан хүүхдүүд лугаа адил болж, мөн Төгс Хүчит Их Эзэн, Христийн цагаатгалын цусаар мөн энэ цусанд аврал байсан, мөн байгаа, мөн байх болно гэдэгт итгэхгүй аваас хүмүүн өөрсдийн бодгалиудад зүхлийг уух болно.
- 19 Учир нь эгэл хүн бол Бурханы дайсан, мөн Адамын уналтаас тийм байсаар ирсэн, мөн тэрээр Ариун Сүнсний таталтанд автагдан, эгэл хүмүүнээ орхиж мөн Их Эзэн Христийн цагаатгалаар гэгээн-тэн болж, хүүхэд шиг хүлцэнгүй, номхон, даруухан, тэвчээртэй, хайраар дүүрэн, бүр хүүхэд эцэгтээ захирагддаг шиг Их Эзэн түүн дээр ноогдуулах бүх зүйлийг хүлцэхэд бэлэн бус аваас үүрд мөн үргэлж тийм байх болно.
- 20 Мөн үүнээс гадна, би та нарт хэлнэ, нэгэн Аврагчийн талаарх мэдлэг бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс бүрийн дунд тархах тэр цаг ирэх болно.
- 21 Мөн болгоогтун, тэр цаг ирэхэд бяцхан хүүхдүүдээс бусад нь, зөвхөн Төгс Хүчит Их Эзэний нэрэнд итгэх итгэл мөн наманчлалаар бус аваас хэн ч Бурханы өмнө буруугүй нь тогтоогдохгүй.
- 22 Мөн бүр та өөрийн хүмүүст Их Эзэн Бурхан чинь танд зарлигласан зүйлийг заасан байх бүр энэ цагт ч, тэр үед ч Бурханы мэлмийд тэдний буруугүй нь дахин тогтоогдохгүй, зөвхөн танд ярьсан миний үгсийн дагуу буюу.
- 23 Мөн эдүгээ Их Эзэн Бурхан надад зарлигласан үгсийг би ярилаа.

And even if it were possible that little children could sin they could not be saved; but I say unto you they are blessed; for behold, as in Adam, or by nature, they fall, even so the blood of Christ atoneth for their sins.

And moreover, I say unto you, that there shall be no other name given nor any other way nor means whereby salvation can come unto the children of men, only in and through the name of Christ, the Lord Omnipotent.

For behold he judgeth, and his judgment is just; and the infant perisheth not that dieth in his infancy; but men drink damnation to their own souls except they humble themselves and become as little children, and believe that salvation was, and is, and is to come, in and through the atoning blood of Christ, the Lord Omnipotent.

For the natural man is an enemy to God, and has been from the fall of Adam, and will be, forever and ever, unless he yields to the enticings of the Holy Spirit, and putteth off the natural man and becometh a saint through the atonement of Christ the Lord, and becometh as a child, submissive, meek, humble, patient, full of love, willing to submit to all things which the Lord seeth fit to inflict upon him, even as a child doth submit to his father.

And moreover, I say unto you, that the time shall come when the knowledge of a Savior shall spread throughout every nation, kindred, tongue, and people.

And behold, when that time cometh, none shall be found blameless before God, except it be little children, only through repentance and faith on the name of the Lord God Omnipotent.

And even at this time, when thou shalt have taught thy people the things which the Lord thy God hath commanded thee, even then are they found no more blameless in the sight of God, only according to the words which I have spoken unto thee.

And now I have spoken the words which the Lord God hath commanded me.

24 Мөн Их Эзэн ийн хэлдэг: Тэдгээр нь энэ хүмүүсийн эсрэг илэрхий гэрчлэл болон шүүлтийн өдөр зогсох болно; ингэснээр тэд, хүн бүр өөр өөрийн үйлүүдийн дагуу, тэд сайнаараа эс бөгөөс хилэнцэтээрээ шүүгдэх болно.

25 Мөн хэрэв тэд хилэнцэт аваас тэд Их Эзэний дэргэдээс зайлан, тэд дахин хэзээ ч буцаж ирж үл чадах зовлонгийн мөн төгсгөлгүй тарчлалын байдалд ороход хүргэх, өөрсдийнхөө гэм болоод жигшүүрт хэргүүдийн аймшигт төсөөлөлд оногдох болно; тиймийн тул тэд бодгалиуддаа зүхлийг уух бөлгөө.

26 Тиймийн тул, тэр хориглогдсон жимснээс хүртсэн учир Адам унах ёстойг шударга ёс цуцалж чадаагүйн адил, тэрчлэн шударга ёс нь тэдний уух ёстойг хэлтрүүлж үл чадах, Бурханы хилэнгийн аяганаас тэд уусан байна; тиймийн тул, тэдний дээр нигүүлсэл дахин байх эрхтэй байж чадахгүй бөлгөө.

27 Мөн тэдний тарчлал дөл унтраагдашгүй, мөн утаа нь үргэлж мөн үүрд уугих тэрхүү галан мөн хүхэрт чулуун нуур лугаа адил байх болно. Тийн Их Эзэн надад зарлигласан билээ. Амен.

And thus saith the Lord: They shall stand as a bright testimony against this people, at the judgment day; whereof they shall be judged, every man according to his works, whether they be good, or whether they be evil.

And if they be evil they are consigned to an awful view of their own guilt and abominations, which doth cause them to shrink from the presence of the Lord into a state of misery and endless torment, from whence they can no more return; therefore they have drunk damnation to their own souls.

Therefore, they have drunk out of the cup of the wrath of God, which justice could no more deny unto them than it could deny that Adam should fall because of his partaking of the forbidden fruit; therefore, mercy could have claim on them no more forever.

And their torment is as a lake of fire and brimstone, whose flames are unquenchable, and whose smoke ascendeth up forever and ever. Thus hath the Lord commanded me. Amen.

## Мозая 4

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Бенжамин Их Эзэний тэнгэр элчээр түүнд хүргэгдсэн үгсийг ярихаа төгсгөл болгоод, эргэн тойрондоо байх хүмүүсийн зүг харц бэлчээж, мөн тэдний дээр ирсэн Их Эзэнээс эмээх айдсын учир тэд газарт унасан байхыг болгоов.
- 2 Мөн тэд өөрсдийгөө зуурдын байдалд буйгаа бүр газрын тоосноос ч өчүүхнээ төсөөлсөн ажгуу. Мөн тэд бүгд нэгэн дуугаар чанга хашгирч, хэлсэн нь: Ай нигүүлсэж хайрла, мөн бид нүглүүддээ өршөөлийг хүлээж авч болохын тулд мөн зүрх сэтгэл маань ариуссан байж болохын тулд Христийн цагаатгагч цусыг нөлөөлүүлээч; учир нь бид Есүс Христэд, тэнгэр ба газар, мөн бүх зүйлийг бүтээсэн Бурханы Хүүд хүмүүний үрсийн дунд доош ирэх түүнд итгэдэг.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэд эдгээр үгсийг ярьсны дараа Их Эзэний Сүнс тэдний дээр ирж, мөн тэд нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч, улмаар тэд ухамсрын амар амгаланг хүлээн авсан учир, мөн тэд баяр хөөрөөр дүүргэгдсэн байв, хаан Бенжамин тэдэнд ярьсан үгсийн дагуу, ирэх ёстой Есүс Христэд итгэх үлэмж итгэл тэдэнд байсны учир бөлгөө.
- 4 Мөн хаан Бенжамин дахин амаа нээж мөн тэдэнд ярьж эхлэв, хэлсэн нь: Нөхөд минь бас ах дүүс минь, миний үндэстэн мөн хүмүүс минь, би та нарын анхаарлыг дахин хүсье, та нарт миний ярих үгсийн үлдсэнийг та нар сонсож мөн ойлгож болохын тулд бөлгөө.
- 5 Учир нь болгоогтун, хэрэв Бурханы сайн сайхны мэдлэг энэ цагт та нарын юу ч бишийг мөн та нарын ашиггүй хийгээд унасан байдлын мэдрэмжид сэрэсэн бол—
- 6 Би та нарт хэлнэ, хэрэв Бурханы сайн сайхан, мөн түүний зүйрлэшгүй хүч, мөн түүний мэргэн ухаан, мөн түүний тэвчээр, мөн түүний хүмүүний үрсэд хандсан тэсвэрийн тухай; мөн түүнчлэн, түүгээр Их Эзэнд найдлага тавьсан мөн түүний зарлигуудыг дагахдаа хичээнгүй байсан, мөн үргэлж, бүр өөрийн амьдралын, би зуурдын биеийн амьдралыг хэлж байна, төгсгөл хүртэл итгэлтэй байсан түүнд аврал ирж болохын тулд, дэлхийн үүслээс бэлтгэгдсэн цагаатгалын тухай мэдлэгт ирсэн бол—

## Mosiah 4

And now, it came to pass that when king Benjamin had made an end of speaking the words which had been delivered unto him by the angel of the Lord, that he cast his eyes round about on the multitude, and behold they had fallen to the earth, for the fear of the Lord had come upon them.

And they had viewed themselves in their own carnal state, even less than the dust of the earth. And they all cried aloud with one voice, saying: O have mercy, and apply the atoning blood of Christ that we may receive forgiveness of our sins, and our hearts may be purified; for we believe in Jesus Christ, the Son of God, who created heaven and earth, and all things; who shall come down among the children of men.

And it came to pass that after they had spoken these words the Spirit of the Lord came upon them, and they were filled with joy, having received a remission of their sins, and having peace of conscience, because of the exceeding faith which they had in Jesus Christ who should come, according to the words which king Benjamin had spoken unto them.

And king Benjamin again opened his mouth and began to speak unto them, saying: My friends and my brethren, my kindred and my people, I would again call your attention, that ye may hear and understand the remainder of my words which I shall speak unto you.

For behold, if the knowledge of the goodness of God at this time has awakened you to a sense of your nothingness, and your worthless and fallen state—

I say unto you, if ye have come to a knowledge of the goodness of God, and his matchless power, and his wisdom, and his patience, and his long-suffering towards the children of men; and also, the atonement which has been prepared from the foundation of the world, that thereby salvation might come to him that should put his trust in the Lord, and should be diligent in keeping his commandments, and continue in the faith even unto the end of his life, I mean the life of the mortal body—

7 Энэ нь Адамын уналтаас хойш байсан, эсвээс байгаа, эсвээс бүр энэ дэлхийн төгсгөлийг хүртэл байх, бүх хүн төрөлхтөнд зориулж дэлхийн үүслээс бэлтгэгдсэн тэрхүү цагаатгалаар авралыг хүлээн авах тэр хүн бол энэ юм гэдгийг би хэлнэ.

8 Мөн энэ нь аврал хэрхэн ирэхийн арга билээ. Мөн энд яригдсанаас өөр аврал гэж үгүй; бас та нарт маний ярьсан тэр нөхцлүүдээс өөр хүмүүн аврагдаж болох ямар ч нөхцөлүүд үгүй.

9 Бурханд итгэ; тэр байдагт итгэ, мөн тэр, тэнгэрт болон газарт аль алин дээрх бүх зүйлийг бүтээсэнд итгэ; тэр бол тэнгэрт мөн газарт аль алинд нь бүх мэргэн ухааныг, мөн бүх хүч чадлыг эзэмшигч гэдэгт итгэ; Их Эзэний ухаарч чадах тэр бүх зүйлийг хүмүүн ухаардаггүйд итгэ.

10 Мөн үүнчлэн, та нар нүглүүдээ наманчилж мөн тэдгээрийг орхих ёстой, мөн өөрсдийгөө Бурханы өмнө даруусгах ёстойг итгэ; мөн тэрээр та нарыг уучлаасай хэмээн чин зүрхнээсээ гуй; мөн эдүгээ, хэрэв та нар эдгээр бүх зүйлд итгэвэл тэдгээрийг өөрсдөө үйлдэхэд анхаарагтун.

11 Мөн би урьд хэлснийхээ адил дахин би та нарт хэлье, та нар Бурханы алдар суугийн мэдлэгт ирсэн шиг, эсвээс хэрэв та нар түүний сайн сайхныг мэдэж мөн түүний хайрыг амталсан, мөн та нарын бодгалиудад үлэмж агуу баясал авчрах, нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авсан бол, тэрчлэн Бурханы агуу ихийг, мөн өөрсдийнхөө юу ч биш болохыг, мөн түүний сайн сайхан хийгээд зохисгүй бүтээлүүд болох та нарт хандсан тэсвэрийг нь та нар үргэлж дурсан санаасай хэмээнэ би, мөн та нар өөрсдийгөө бүр даруу байдлын гүнд даруусгаж, Их Эзэний нэрийг өдөр тутам дуудан, мөн тэнгэр элчийн амаар яригдсан тэрхүү ирэх зүйлд итгэх сүсэг бишрэлд гуйвшгүйгээр зогсоосой хэмээнэ.

12 Мөн болгоогтун, хэрэв та нар үүнийг хийвээс та нар үргэлж баясна, мөн Бурханы хайраар дүүргэгдэж, мөн нүглүүдийнхээ ангижралыг үргэлж хадгалах болно хэмээн би та нарт хэлнэ; мөн та нарыг бүтээсэн түүний алдар суугийн мэдлэгт, эсвээс шударга бөгөөд үнэн болох түүний мэдлэгт та нар өсөх болно.

I say, that this is the man who receiveth salvation, through the atonement which was prepared from the foundation of the world for all mankind, which ever were since the fall of Adam, or who are, or who ever shall be, even unto the end of the world.

And this is the means whereby salvation cometh. And there is none other salvation save this which hath been spoken of; neither are there any conditions whereby man can be saved except the conditions which I have told you.

Believe in God; believe that he is, and that he created all things, both in heaven and in earth; believe that he has all wisdom, and all power, both in heaven and in earth; believe that man doth not comprehend all the things which the Lord can comprehend.

And again, believe that ye must repent of your sins and forsake them, and humble yourselves before God; and ask in sincerity of heart that he would forgive you; and now, if you believe all these things see that ye do them.

And again I say unto you as I have said before, that as ye have come to the knowledge of the glory of God, or if ye have known of his goodness and have tasted of his love, and have received a remission of your sins, which causeth such exceedingly great joy in your souls, even so I would that ye should remember, and always retain in remembrance, the greatness of God, and your own nothingness, and his goodness and long-suffering towards you, unworthy creatures, and humble yourselves even in the depths of humility, calling on the name of the Lord daily, and standing steadfastly in the faith of that which is to come, which was spoken by the mouth of the angel.

And behold, I say unto you that if ye do this ye shall always rejoice, and be filled with the love of God, and always retain a remission of your sins; and ye shall grow in the knowledge of the glory of him that created you, or in the knowledge of that which is just and true.

- 13 Мөн бие биенээ гомдоох биш, харин амар амгалангаар амьдрах, мөн хүн бүрд өөрийн өр төлөөсний дагуу төлөх санаа та нарт бий болно.
- 14 Мөн та нар хүүхдүүдээ өлсгөлөн, эсвээс нүцгэн явахыг тэвчихгүй болой; бас тэд Бурханы хуулиудыг зөрчихийг, мөн нэг нэгэнтэйгээ байлдан мөн тэмцэх, мөн нүглийн эзэн болох, өөрөөр хэлбэл бидний эцэг өвгөдийн ярьдаг байсан муу ёрын сүнс чөтгөрт үйлчлэхийг зөвшөөрөхгүй, учир нь тэр бол бүх зөв шударгын дайсан билээ.
- 15 Харин үнэний мөн чанд байдлын замуудаар алхалхыг та нар тэдэнд заах болно; бие биенээ хайрлах, мөн ндээ үйлчлэхийг та нар тэдэнд заах болно.
- 16 Мөн түүнчлэн, та нарын халамжаар гачигдах тэднийг та нар өөрсдөө халамжлах болно; та нар өөрсдийн хөрөнгөнөөс гачигдаж байгаа түүнд өгөх болно; мөн та нар гуйлгачны хүсэлтийг хоосон буцааж тэвчихгүй, мөн түүнийг мөхөл уруу нь хөөхгүй байх болно.
- 17 Магад та нар хэлнэ: Хүн зовлонгоо өөр дээрээ авчирдаг; тиймийн тул би гараа татаж, мөн түүнд хүнснээсээ өгөхгүй, бас тэрбээр зовохгүй байж болохын тулд хөрөнгөнөөсөө ч түүнд хүртээхгүй, учир нь түүний шийтгэлүүд шударга—
- 18 Гэвч би та нарт хэлнэ, Ай хүмүүн, үүнийг хийх хэн боловч, мөнхүү тэр нь наманчлах агуу шалтгаантай байдаг; мөн тэр хийсэн зүйлээ наманчлахгүй бол тэрээр үүрд мөхөж мөн Бурханы хаант улсад хамаагүй байх болно.
- 19 Учир нь болгоогтун, бид бүгд гуйлгачид бус уу? Бид бүгд нэгэн адил Бие, бүр Бурханаас хамаардаг, бидэнд байгаа бүх хөрөнгө, хоол хүнс мөн хувцас хунар, мөн алт, мөн мөнгө, мөн бидэнд байгаа төрөл бүрийн бүх баялгууд түүнээс бус гэж үү
- 20 Мөн болгоогтун, бүр энэ цагт, та нар түүний нэрийг дуудаж, мөн нүглүүддээ ангижралыг гуйж байна. Мөн тэрээр хоосон гуйхыг та нарт зөвшөөрсөн үү? Үгүй; тэр өөрийн Сүнсийг та нарын дээр цутгаж, мөн та нарын зүрх сэтгэл баяраар дүүргэгдэхээр болгож, мөн та нар ийм үлэмжийн агуу баяслаа илэрхийлэх арга олж чадахгүйд хүргэн та нарын амыг хамхисан байхаар болгосон буюу.

And ye will not have a mind to injure one another, but to live peaceably, and to render to every man according to that which is his due.

And ye will not suffer your children that they go hungry, or naked; neither will ye suffer that they transgress the laws of God, and fight and quarrel one with another, and serve the devil, who is the master of sin, or who is the evil spirit which hath been spoken of by our fathers, he being an enemy to all righteousness.

But ye will teach them to walk in the ways of truth and soberness; ye will teach them to love one another, and to serve one another.

And also, ye yourselves will succor those that stand in need of your succor; ye will administer of your substance unto him that standeth in need; and ye will not suffer that the beggar putteth up his petition to you in vain, and turn him out to perish.

Perhaps thou shalt say: The man has brought upon himself his misery; therefore I will stay my hand, and will not give unto him of my food, nor impart unto him of my substance that he may not suffer, for his punishments are just—

But I say unto you, O man, whosoever doeth this the same hath great cause to repent; and except he repenteth of that which he hath done he perisheth forever, and hath no interest in the kingdom of God.

For behold, are we not all beggars? Do we not all depend upon the same Being, even God, for all the substance which we have, for both food and raiment, and for gold, and for silver, and for all the riches which we have of every kind?

And behold, even at this time, ye have been calling on his name, and begging for a remission of your sins. And has he suffered that ye have begged in vain? Nay; he has poured out his Spirit upon you, and has caused that your hearts should be filled with joy, and has caused that your mouths should be stopped that ye could not find utterance, so exceedingly great was your joy.

21 Мөн эдүгээ, хэрэв Бурхан, та нарыг бүтээсэн тэрбээр, та нарын амьдрал мөн та нарт байгаа бүхэн, та нар бүхлээрээ хамаарах тэрбээр, та нарын итгэлтэйгээр хүлээн авах болно гэдэгт итгэн гуйсан зөв болох юуг ч та нарт хайрладаг бол, Ай тэгвэл, та нар өөрсдөдөө байгаа хөрөнгөнөөс нэг нэгэнтэйгээ хуваалцаж нь хичнээн их зохистой билээ.

22 Мөн тэрээр мөхөхгүйн тул чамд хандан хөрөнгөнөөс чинь гуйх хүнийг та нар шүүн, мөн түүнийг буруутгах аваас, та нарт бус, харин та нарын амьдрал ч түүнчлэн түүнд хамаарагдах тэр Бурханд харъяалагдах эд хөрөнгөө харамласны улмаас хүртэх та нарын буруушаалт хэр зэрэг илүү шударга байх билээ; гэсэн хэдий ч, та нар гуйлга гуйх нь, бас хийсэн тэр зүйлээ наманчлах нь үгүй бөлгөө.

23 Би та нарт хэлнэ, тэр хүнд халаг, учир нь түүний хөрөнгө түүнтэй хамт мөхөх болно; мөн эдүгээ, би эдгээр зүйлийг энэ дэлхийн зүйлүүдэд хамаарагдах зүйлээр баян тэдэнд хэлж байна.

24 Мөн үүнчлэн, би ядууст, эд хөрөнгөгүй боловч шар наран бор хоногийг хоолтой өнгөрөөх та нарт хэлнэ; та нарт байгаагүйн учир гуйлгачныг буцаах та нарыг бүгдийг чинь би хэлж байна; та нарыг зүрх сэтгэлдээ ингэж хэлээсэй хэмээнэ би: Надад байгаагүй учраас би өгөөгүй, харин хэрэв надад байсан бол би өгөх байсан.

25 Мөн эдүгээ, хэрэв та нар зүрх сэтгэлдээ ийн хэлбэл та нар гэмгүй үлдэнэ, эс тэгвэл та нар буруушаагдана; мөн та нар хүлээн аваагүй тэр юманд шунасны учир та нарын авах буруушаалт шударга байх буюу.

26 Мөн эдүгээ, та нарт миний ярьсан эдгээр зүйлүүдийн учир—өөрөөр хэлбэл, та нар Бурханы өмнө гэмгүйгээр алхаж болохын тулд өдрөөс өдөрт нүглүүдийнхээ ангижралыг хадгалан үлдэхийн төлөө— та нар хүн бүр байгаагийнхаа хэрээр ядуустай хөрөнгөө хуваалцаасай хэмээнэ би, өлссөнийг хооллох, нүцгэнийг хувцаслах, өвчтэйд очиж мөн сүнсийг нь мөн биесийг нь ч аль алиныг нь, хүссэнийх нь дагуу тэднийг асрах зэрэг болой.

And now, if God, who has created you, on whom you are dependent for your lives and for all that ye have and are, doth grant unto you whatsoever ye ask that is right, in faith, believing that ye shall receive, O then, how ye ought to impart of the substance that ye have one to another.

And if ye judge the man who putteth up his petition to you for your substance that he perish not, and condemn him, how much more just will be your condemnation for withholding your substance, which doth not belong to you but to God, to whom also your life belongeth; and yet ye put up no petition, nor repent of the thing which thou hast done.

I say unto you, wo be unto that man, for his substance shall perish with him; and now, I say these things unto those who are rich as pertaining to the things of this world.

And again, I say unto the poor, ye who have not and yet have sufficient, that ye remain from day to day; I mean all you who deny the beggar, because ye have not; I would that ye say in your hearts that: I give not because I have not, but if I had I would give.

And now, if ye say this in your hearts ye remain guiltless, otherwise ye are condemned; and your condemnation is just for ye covet that which ye have not received.

And now, for the sake of these things which I have spoken unto you—that is, for the sake of retaining a remission of your sins from day to day, that ye may walk guiltless before God—I would that ye should impart of your substance to the poor, every man according to that which he hath, such as feeding the hungry, clothing the naked, visiting the sick and administering to their relief, both spiritually and temporally, according to their wants.



- 27 Мөн эдгээр бүх зүйл мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийгддэг байхыг мэдэгтүн; учир нь хүн өөрт нь буй хүчнээс илүү хурдан гүйх шаардлагагүй. Мөн үүнчлэн, тэрээр хичээнгүй байх шаардлагатай, тэгснээр тэр шагналыг хожиж болохын тулд бөлгөө; тиймийн тул бүх зүйл эмх цэгцэнд хийгдэх ёстой.
- 28 Мөн та нарын дунд хөршөөсөө зээлсэн хэн боловч зээлсэн тэр зүйлээ тохирсны дагуу эргүүлж өгөх ёстой, эсвээс та нүгэл үйлдэх болно; мөн магад та өөрийн хөршийг түүнчлэн нүгэл үйлдэхэд хүргэх вий гэдгийг та нар санаасай хэмээнэ би.
- 29 Мөн эцэст нь, та нар тэгснээр нүгэл үйлдэж болох зүйлийг бүгдийг би та нарт хэлж чадахгүй; учир нь маш олон янзын зам мөн аргууд бий, бүр тэдгээрийг би тоолж чадахааргүй тийм олон бөлгөө.
- 30 Гэвч өдий зэргийг би та нарт хэлж чадна, хэрэв та нар өөрсдийгөө, мөн бодлуудаа, мөн үгсээ, мөн үйлүүдээ хянаж, мөн Бурханы зарлигуудыг мөрдөж, бас Их Эзэний маань ирэлтийн талаар сонссон түүндээ үргэлж итгэлтэй байж, бүр амьдралынхаа эцсийг хүртэл ингэхгүй аваас, та нар мөхөх ёстой болно. Мөн эдүгээ, Ай хүмүүн, санагтун, мөн бүү мөхөгтүн.

And see that all these things are done in wisdom and order; for it is not requisite that a man should run faster than he has strength. And again, it is expedient that he should be diligent, that thereby he might win the prize; therefore, all things must be done in order.

And I would that ye should remember, that whosoever among you borroweth of his neighbor should return the thing that he borroweth, according as he doth agree, or else thou shalt commit sin; and perhaps thou shalt cause thy neighbor to commit sin also.

And finally, I cannot tell you all the things whereby ye may commit sin; for there are divers ways and means, even so many that I cannot number them.

But this much I can tell you, that if ye do not watch yourselves, and your thoughts, and your words, and your deeds, and observe the commandments of God, and continue in the faith of what ye have heard concerning the coming of our Lord, even unto the end of your lives, ye must perish. And now, O man, remember, and perish not.

## Мозая 5

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Бенжамин өөрийн хүмүүст тийн яриад, тэд өөрсдөд нь түүний ярьсан үгэнд итгэсэн эсэхийг мэдэхийг тэрээр хүсэн тэдний дунд илгээсэн бөлгөө.
- 2 Мөн тэд бүгд нэгэн дуугаар хашгирч, өгүүлсэн нь: Тийм ээ, бидэнд ярьсан тэр бүх үгсэд тань бид итгэнэ; мөн түүнчлэн, бидэнд хилэнцийг үйлдэх хүслийг үгүй болгох, харин үргэлж сайныг хийх болгон, бидэнд, өөрөөр хэлбэл бидний зүрх сэтгэлд хүчирхэг өөрчлөлтийг үйлдсэн Төгс Хүчитг Их Эзэний Сүнсний учир тэдгээрийн гарцаагүйг мөн үнэнийг бид мэднэ.
- 3 Мөн бид, өөрсдөө, түүнчлэн, Бурханы хэмжээлшгүй сайн сайхнаар, мөн түүний Сүнсний илэрхийллүүдээр, ирэх тэр зүйлүүдийн агуу үзэгдлүүдийг хүлээн авдаг; мөн энэ нь зохист байсан бол бид бүх зүйлийн тухай бошиглож чадах сан билээ.
- 4 Мөн биднийг ийм үлэмжийн агуу баяраар баярлах болгосон нь, энэ агуу мэдлэгт биднийг авчирсан нь манай хааны ярьсан зүйлүүдэд бидний хадгалах тэрхүү итгэл бөлгөө.
- 5 Мөн бид өөрсдийгөө тэнгэр элчүүдээр яригдсан шиг төгсгөлгүй зовлонд авчрахгүй байж болохын тулд, бид Бурханы хилэнгийн аяганаас уухгүй байж болохын тулд бид үлдсэн бүх өдрүүддээ бидэнд түүний зарлиглах, бүх зүйлд, түүний зарлигуудад дуулгавартай байж, Бурхантайгаа түүний тааллыг гүйцэлдүүлэх гэрээ хийхэд бэлэн байна.
- 6 Мөн эдүгээ, эдгээр нь хаан Бенжамин тэднээс хүссэн үгс; мөн тиймийн тул тэрээр тэдэнд хэлэв: Та нар миний хүссэн үгсийг ярилаа; мөн та нарын хийсэн тэрхүү гэрээ бол зөв шударга гэрээ болой.
- 7 Мөн эдүгээ, та нарын хийсэн гэрээний учир та нар Христийн хүүхдүүд, түүний хөвгүүд, мөн түүний охид гэж нэрлэгдэх болно; учир нь болгоогтун, энэ өдөр тэрээр та нарыг оюун санаагаар тань төрүүлээ; учир нь та нарын зүрх сэтгэл түүний нэрэнд итгэх итгэлээр өөрчлөгдсөн хэмээн та нар хэллээ; тиймийн тул, та нар түүнээс төрсөн мөн түүний хөвгүүд мөн түүний охид болсон бөлгөө.

## Mosiah 5

And now, it came to pass that when king Benjamin had thus spoken to his people, he sent among them, desiring to know of his people if they believed the words which he had spoken unto them.

And they all cried with one voice, saying: Yea, we believe all the words which thou hast spoken unto us; and also, we know of their surety and truth, because of the Spirit of the Lord Omnipotent, which has wrought a mighty change in us, or in our hearts, that we have no more disposition to do evil, but to do good continually.

And we, ourselves, also, through the infinite goodness of God, and the manifestations of his Spirit, have great views of that which is to come; and were it expedient, we could prophesy of all things.

And it is the faith which we have had on the things which our king has spoken unto us that has brought us to this great knowledge, whereby we do rejoice with such exceedingly great joy.

And we are willing to enter into a covenant with our God to do his will, and to be obedient to his commandments in all things that he shall command us, all the remainder of our days, that we may not bring upon ourselves a never-ending torment, as has been spoken by the angel, that we may not drink out of the cup of the wrath of God.

And now, these are the words which king Benjamin desired of them; and therefore he said unto them: Ye have spoken the words that I desired; and the covenant which ye have made is a righteous covenant.

And now, because of the covenant which ye have made ye shall be called the children of Christ, his sons, and his daughters; for behold, this day he hath spiritually begotten you; for ye say that your hearts are changed through faith on his name; therefore, ye are born of him and have become his sons and his daughters.

- 8 Мөн энэ нэрэн дор та нар эрх чөлөөтэй болгогдсон, мөн үүнээс өөр та нар чөлөөт болгогдож чадах нэр үгүй билээ. Түүгээр аврал ирэх үүнээс өөр нэр гэж үгүй; тиймийн тул, та нарыг, амьдралынхаа төгсгөлийг хүртэл дуулгавартай байхаар Бурхантай гэрээнд орсон та нар бүгдийг Христийн нэрийг өөрсөд дээрээ хүлээн аваасай хэмээнэ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор үүнийг хийсэн нь Бурханы баруун гар талд олдох болно, учир нь тэрээр өөрийн нэрлэгдсэн нэрээ мэдэх болно; учир нь тэрээр Христийн нэрээр нэрлэгдэх болно.
- 10 Мөнхүү улиран тохиох дор, Христийн нэрийг өөр дээрээ авахгүй хэн боловч өөр ямар нэгэн нэрээр нэрлэгдэх ёстой; тиймийн тул, тэрээр Бурханы зүүн гар талд өөрийгөө олох буюу.
- 11 Мөн энэ бол та нарт миний өгвөл зохино гэсэн, зөрчлөөс бусдаар бол хэзээ ч арилгагдахгүй нэр гэдгийг түүнчлэн та нар санаасай хэмээнэ би; тиймийн тул, уг нэр та нарын зүрх сэтгэлээс арилгагдахгүйн тулд, зөрчил гаргахгүй байхад анхаарагтун.
- 12 Би та нарт хэлнэ, та нар Бурханы зүүн гар талд олдохгүйн тулд, харин та нар өөрсдийн дуудагдах дуу хоолойг, мөн түүнчлэн та нарыг дуудах нэрийг сонсож бас мэдэхийн тулд уг нэрийг зүрх сэтгэлдээ үргэлж бичээстэй нь хадгалахыг та нар санаасай хэмээнэ би.
- 13 Учир нь өөрийн үйлчилж байгаагүй, өөрийн танихгүй нэгэн болох, мөн зүрх сэтгэлийн бодол хийгээд зорилтоос нь хол байх эзнээ хүн хэрхэн мэдэх билээ
- 14 Мөн түүнчлэн, хүн хөршид нь харъяалагдах илжгийг авч өөртөө үлдээх үү? Би та нарт хэлнэ, Үгүй; тэрээр түүнийг сүргийнхээ дунд тэжээхийг ч зөвшөөрөхгүй, харин түүнийг гадагш тууж, зайлуулах болно. Би та нарт хэлнэ, энэ нь хэрэв та нар нэрлэгдэх нэрээ эс мэдвээс та нарын хувьд ч энэчлэн байх болно.

And under this head ye are made free, and there is no other head whereby ye can be made free. There is no other name given whereby salvation cometh; therefore, I would that ye should take upon you the name of Christ, all you that have entered into the covenant with God that ye should be obedient unto the end of your lives.

And it shall come to pass that whosoever doeth this shall be found at the right hand of God, for he shall know the name by which he is called; for he shall be called by the name of Christ.

And now it shall come to pass, that whosoever shall not take upon him the name of Christ must be called by some other name; therefore, he findeth himself on the left hand of God.

And I would that ye should remember also, that this is the name that I said I should give unto you that never should be blotted out, except it be through transgression; therefore, take heed that ye do not transgress, that the name be not blotted out of your hearts.

I say unto you, I would that ye should remember to retain the name written always in your hearts, that ye are not found on the left hand of God, but that ye hear and know the voice by which ye shall be called, and also, the name by which he shall call you.

For how knoweth a man the master whom he has not served, and who is a stranger unto him, and is far from the thoughts and intents of his heart?

And again, doth a man take an ass which belongeth to his neighbor, and keep him? I say unto you, Nay; he will not even suffer that he shall feed among his flocks, but will drive him away, and cast him out. I say unto you, that even so shall it be among you if ye know not the name by which ye are called.

15 Тиймийн тул, тэнгэр ба газарт орших бүх зүйлийг бүтээсэн, бүхний дээрх Бурхан болох түүний мэргэн ухаан хийгээд хүч, мөн шударга ёс, мөн нигүүлслээр та нар үүрдийн аврал хийгээд мөнх амьдралыг авч болохын тулд, та нар тэнгэрт авчрагдаж болохын тулд, Христ, Төгс Хүчит Их Эзэн Бурхан та нарыг өөрийнх байлгахаар лацдаж болохын тулд, та нарыг хичээнгүй мөн гуйвшгүй байж, сайн үйлүүдээр үргэлж бялхаасай хэмээнэ би. Амен.

Therefore, I would that ye should be steadfast and immovable, always abounding in good works, that Christ, the Lord God Omnipotent, may seal you his, that you may be brought to heaven, that ye may have everlasting salvation and eternal life, through the wisdom, and power, and justice, and mercy of him who created all things, in heaven and in earth, who is God above all. Amen.

## Мозая 6

- 1 Мөн эдүгээ, хаан Бенжамин хүмүүст ярьж дууссаны-  
хаа дараа, зарлигуудыг нь дагахаар Бурхантай гэр-  
рэнд орсон тэд бүгдийн нэрсийг тэрээр авбал зохи-  
но хэмээн бодов.
- 2 Мөнхүү улиран тохиох дор бяцхан хүүхдүүдээс  
бусад нь, гэрээнд орж мөн Христийн нэрийг өөрс-  
дийн дээр аваагүй нэгээхэн ч бодгаль байсангүй.
- 3 Мөн түүнчлэн, улиран тохиох дор хаан Бенжамин  
эдгээр бүх зүйлийн төгсгөлийг үйлдэж, мөн хүү  
Мозаягаа өөрийн хүмүүсийн дээр захирагч бөгөөд  
хаан байхаар томилон адисалж, мөн түүнд хаант ул-  
сын талаарх бүх хариуцлагыг өгөв, мөн түүнчлэн тэд  
Бурханы зарлигуудыг сонсож бас мэдэж болох бөг-  
өөд тэднийг өөрсдийнх нь өргөсөн тангаргийг сана-  
хад өдөөн хатгахын тулд хүмүүст сургах санваарт-  
нуудыг томилоод, тэрээр олон ардыг тарааж мөн  
тэд, хүн бүр, өөр өөрийн гэр бүлд, гэртээ буцацгаав.
- 4 Мөн Мозая эцгийнхээ оронд засаглаж эхлэв. Мөн  
тэрээр гучин насандаа засаглаж эхэлсэн болой, бү-  
хэлдээ Лихай Иерусалимыг орхисон цагаас ойрол-  
цоогоор дөрвөн зуун далан зургаан жил болжээ.
- 5 Мөн хаан Бенжамин гурван жил амьдраад мөн тэр-  
рээр нас барав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая Их  
Эзэний замуудаар алхаж, мөн түүний шийдвэрүү-  
дийг мөн түүний тогтоолуудыг мөрдөн, мөн түүний  
зарлигуудыг тэрээр түүнд зарлигласан юунд ч болов  
бүх зүйлд дагав.
- 7 Мөн хаан Мозая өөрийн хүмүүсийг тэд газрыг бо-  
ловсруулахаар болгов. Мөн тэрээр түүнчлэн, өөрөө,  
газар боловсруулж, тэгснээр тэрээр өөрийн хүмүүст  
ачаа болохгүйн тулд, тэрээр бүх зүйлд эцгийнхээ  
хийж байсны дагуу хийж болохын тулд буюу. Мөн  
гурван жилийн турш түүний бүх хүмүүсийн дунд  
зөрчилдөөн байсангүй.

## Mosiah 6

And now, king Benjamin thought it was expedient, af-  
ter having finished speaking to the people, that he  
should take the names of all those who had entered into  
a covenant with God to keep his commandments.

And it came to pass that there was not one soul, ex-  
cept it were little children, but who had entered into  
the covenant and had taken upon them the name of  
Christ.

And again, it came to pass that when king Benjamin  
had made an end of all these things, and had conse-  
crated his son Mosiah to be a ruler and a king over his  
people, and had given him all the charges concerning  
the kingdom, and also had appointed priests to teach  
the people, that thereby they might hear and know the  
commandments of God, and to stir them up in remem-  
brance of the oath which they had made, he dismissed  
the multitude, and they returned, every one, according  
to their families, to their own houses.

And Mosiah began to reign in his father's stead. And  
he began to reign in the thirtieth year of his age, making  
in the whole, about four hundred and seventy-six years  
from the time that Lehi left Jerusalem.

And king Benjamin lived three years and he died.

And it came to pass that king Mosiah did walk in the  
ways of the Lord, and did observe his judgments and his  
statutes, and did keep his commandments in all things  
whatsoever he commanded him.

And king Mosiah did cause his people that they  
should till the earth. And he also, himself, did till the  
earth, that thereby he might not become burdensome  
to his people, that he might do according to that which  
his father had done in all things. And there was no con-  
tention among all his people for the space of three years.

## Мозая 7

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Мозая гурван жилийн турш үргэлжилсэн амгалангийн дараа, тэрээр Лихай-Нифайн нутагт, өөрөөр хэлбэл Лихай-Нифайн хотод оршин суухаар явсан хүмүүсийн талаар мэдэх хүсэлтэй байв; учир нь түүний хүмүүс тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас хойш тэднээс юухан ч дуулсангүй; тиймийн тул, тэд байнгын гуйлтаараа түүнийг ядраасан ажээ.
- 2 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая хүчит эрсээс арван зургааг нь Лихай-Нифайн нутаг өөд, ах дүүсийнхээ талаар сураглахаар явж болохыг зөвшөөрөв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэд маргааш нь өгсөн явж эхэлсэн аж, тэдэнтэй Аммон гэгч нэгэн байв, тэрээр хүчтэй мөн чадалтай эр, мөн Зарахемлагийн удам байв; мөн тэрээр түүнчлэн тэдний удирдагч байлаа.
- 4 Мөн эдүгээ, тэд Лихай-Нифайн нутаг өөд очихын тулд аглаг буйдад аялах ёстой замаа мэдсэнгүй; тиймийн тул тэд олон өдөр аглаг буйдад бэдрэв, бүр дөчин өдөр тэд бэдэрсэн ажгуу.
- 5 Мөн тэд дөчин өдөр бэдрээд Шиломын нутгийн умардад байх нэгэн толгой дээр ирэв, мөн тэнд тэд майхнуудаа босгов.
- 6 Мөн Аммон ах дүүсээсээ гурвыг нь авч, тэдний нэрийг Амаликай, Хелем, Хем гэдэг байв, мөн тэд Нифайн нутагт уруудан одлоо.
- 7 Мөн болгоогтун, тэд Нифайн нутагт, мөн Шиломын нутагт байсан хүмүүсийн хаантай уулзав; мөн тэд хааны харуулуудаар бүслэгдэн, мөн баривчлагдаж, мөн хүлэгдэж, мөн шоронд хоригдсон ажээ.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд шоронд хоёр өдөр байсны дараа дахин хааны өмнө авчрагдаж, мөн тэдний хүлэг нь тайлагдав; мөн тэд хааны өмнө зогсож, мөн тэднээс түүний асуух асуултанд хариулахаар зөвшөөрөгдсөн байв, эсвээс зарлиглуулсан болой.
- 9 Мөн тэрээр тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, би бол Лимхай, өөрсдийн эцэг өвгөдийн нутаг асан, энэ нутгийг өвлөхөөр Зарахемлагийн нутгаас гарч ирсэн тэрбээр, хүмүүсийн саналаар хаан болгогдсон Зенифийн хүү асан Ноагийн хүү билээ.

## Mosiah 7

And now, it came to pass that after king Mosiah had had continual peace for the space of three years, he was desirous to know concerning the people who went up to dwell in the land of Lehi-Nephi, or in the city of Lehi-Nephi; for his people had heard nothing from them from the time they left the land of Zarahemla; therefore, they wearied him with their teasings.

And it came to pass that king Mosiah granted that sixteen of their strong men might go up to the land of Lehi-Nephi, to inquire concerning their brethren.

And it came to pass that on the morrow they started to go up, having with them one Ammon, he being a strong and mighty man, and a descendant of Zarahemla; and he was also their leader.

And now, they knew not the course they should travel in the wilderness to go up to the land of Lehi-Nephi; therefore they wandered many days in the wilderness, even forty days did they wander.

And when they had wandered forty days they came to a hill, which is north of the land of Shilom, and there they pitched their tents.

And Ammon took three of his brethren, and their names were Amaleki, Helem, and Hem, and they went down into the land of Nephi.

And behold, they met the king of the people who were in the land of Nephi, and in the land of Shilom; and they were surrounded by the king's guard, and were taken, and were bound, and were committed to prison.

And it came to pass when they had been in prison two days they were again brought before the king, and their bands were loosed; and they stood before the king, and were permitted, or rather commanded, that they should answer the questions which he should ask them.

And he said unto them: Behold, I am Limhi, the son of Noah, who was the son of Zeniff, who came up out of the land of Zarahemla to inherit this land, which was the land of their fathers, who was made a king by the voice of the people.

- 10 Мөн эдүгээ, та нар намайг, өөрийн биеэр, харуу-  
луудтайгаа хэрмийн гадна байхад юуны учир хотын  
хэрмэнд ойртон ирэх зориг гаргасан билээ гэдгийг  
мэдэхийг би хүснэ
- 11 Мөн эдүгээ, би та нараас асууж болно хэмээх энэ  
шалтгааны учир би та нарыг хадгалахыг зөвшөөрсөн  
юм эс бөгөөс би та нарыг үхүүл хэмээн харуулууддаа  
тушаах ёстой байсан. Та нарт ярих нь зөвшөөрөгд-  
лөө.
- 12 Мөн эдүгээ, Аммон ярихыг зөвшөөрөгдсөнийг  
хараад, тэрээр дөхөж очин хааны өмнө бөхийв; мөн  
буцан өндийгөөд тэрээр хэлэв: Ай хаантан, би амьд  
байж, мөн ярихаар зөвшөөрөгдсөний учир энэ өдөр  
Бурханы өмнө ихэд талархана; мөн би зоригтойгоор  
ярихыг хичээх болно;
- 13 Учир нь хэрэв та нар намайг мэддэг байсан аваас  
та нар намайг ингэж хүлээсээр хүлэхийг зөвшөөрөх-  
гүй байсныг би лавтайяа мэднэ. Учир нь би Аммон,  
мөн Зарахемлагийн удам, мөн Зениф тэр нутгаас  
гарган авчирсан ах дүүсийнхээ талаар сураглахаар  
Зарахемлагийн нутгаас гарч ирсэн бөлгөө.
- 14 Мөн эдүгээ, улиран тохиох дор Лимхай, Аммоны  
үгсийг сонссоны дараа, тэрээр үлэмж баярлан, мөн  
хэлэв: Эдүгээ, Зарахемлагийн нутагт байсан ах дүү  
нар минь одоо болтол амьд гэдгийг би лавтайяа мэд-  
лээ. Мөн эдүгээ, би баясах болно; мөн маргааш би  
өөрийн хүмүүсийг түүнчлэн баясгана.
- 15 Учир нь болгоогтун, бид леменчүүдийн боолч-  
лолд байж, мөн үүрэхэд хүнд татварыг татварлуулж  
буй. Мөн эдүгээ, болгоогтун, ах дүүс маань биднийг  
боолчлолоос, эсвээс леменчүүдийн гараас гаргаж  
авах болно, мөн бид тэдний боолууд байх болно;  
учир нь бид нифайчуудад боол байх нь леменчүү-  
дийн хаанд алба төлөхөөс хавьгүй дээр болой.
- 16 Мөн эдүгээ, хаан Лимхай өөрийн харуулуудад тэд  
Аммоныг бас түүний ах дүүсийг нь ч ахин хүлэх ёс-  
гүйг зарлиглав, харин тэд Шиломын умардад байх  
толгой уруу явж, мөн тэд идэж, ууж, мөн аяны ал-  
жаалаа тайлж болохын тулд тэдний ах дүүсийг хотод  
авчрахыг тушаав; учир нь тэд олон зүйлийг тэвчсэн  
байв; тэд өлсгөлөн, цангалтыг мөн зүдрэлийг тэвч-  
сэн буюу.

And now, I desire to know the cause whereby ye were  
so bold as to come near the walls of the city, when I, my-  
self, was with my guards without the gate?

And now, for this cause have I suffered that ye should  
be preserved, that I might inquire of you, or else I  
should have caused that my guards should have put you  
to death. Ye are permitted to speak.

And now, when Ammon saw that he was permitted  
to speak, he went forth and bowed himself before the  
king; and rising again he said: O king, I am very thank-  
ful before God this day that I am yet alive, and am per-  
mitted to speak; and I will endeavor to speak with bold-  
ness;

For I am assured that if ye had known me ye would  
not have suffered that I should have worn these bands.  
For I am Ammon, and am a descendant of Zarahemla,  
and have come up out of the land of Zarahemla to in-  
quire concerning our brethren, whom Zeniff brought  
up out of that land.

And now, it came to pass that after Limhi had heard  
the words of Ammon, he was exceedingly glad, and  
said: Now, I know of a surety that my brethren who  
were in the land of Zarahemla are yet alive. And now, I  
will rejoice; and on the morrow I will cause that my peo-  
ple shall rejoice also.

For behold, we are in bondage to the Lamanites, and  
are taxed with a tax which is grievous to be borne. And  
now, behold, our brethren will deliver us out of our  
bondage, or out of the hands of the Lamanites, and we  
will be their slaves; for it is better that we be slaves to the  
Nephites than to pay tribute to the king of the  
Lamanites.

And now, king Limhi commanded his guards that  
they should no more bind Ammon nor his brethren,  
but caused that they should go to the hill which was  
north of Shilom, and bring their brethren into the city,  
that thereby they might eat, and drink, and rest them-  
selves from the labors of their journey; for they had  
suffered many things; they had suffered hunger, thirst,  
and fatigue.

- 17 Мөн эдүгээ, улиран тохиох дор маргааш нь хаан Лимхай өөрийн бүх хүмүүсийн дунд зар бичиг илгээв, тэгснээр түүний тэдэнд ярих үгсийг сонсохоор тэд ариун сүмд өөрсдөө нэгдэн цугларцгааж болохын тулд билээ.
- 18 Мөнхүү улиран тохиох дор тэднийг цуглармагц тэрээр тэдэнд хандан энэ маягаар ярьж, өгүүлсэн нь: Ай та нар, хүмүүс минь, тэргүүнээ өргөгтүн мөн тайтгар; учир нь болгоогтун, бид дайснуудынхаа эрхшээлд байхаа болих тэр цаг ойртлоо, эсвээс холгүй боллоо, талаар өнгөрсөн бидний олон тэмцэл байсан хэдий ч; хойшид тэмцэл маань үр дүнд хүрэх буйза хэмээн найдна би.
- 19 Тиймийн тул, тэргүүнээ өргөцгөө, мөн баяс, мөн найдлагаа Бурханд, Абрахам, мөн Исаак, мөн Иаковын Бурхан байсан тэрхүү Бурханд хандуул; мөн түүнчлэн, Израилын хүүхдүүдийг Египетийн нутгаас гаргаж авчирсан, мөн тэднийг Улаан Тэнгисийг гатлан хуурай газар дээгүүр алхах болгосон, мөн тэд аглаг буйдад мөхөхгүй байж болохын тулд, тэднийг маннагаар хооллосон тэрхүү Бурхан билээ; мөн тэрээр тэдний төлөө өөр олон зүйлийг хийсэн юм.
- 20 Мөн түүнчлэн, эл Бурхан бидний эцэг өвгөдийг Иерусалим нутгаас гарган авчирсан, мөн өөрийн хүмүүсийг бүр өдий болтол хамгаалж мөн хадгалсан болой; мөн болгоогтун, энэ нь бидний алдсууд мөн жигшүүрт хэргүүдийн учир тэрээр биднийг боолчлолд оруулсан болой.
- 21 Мөн энэ өдөр та нар бүгд үүний гэрчүүд, энэ хүмүүсийн дээр хаан болгогдсон тэр Зениф, тэрээр эцэг өвгөдийнхөө нутгийг өвлөх дэндүү их хүсэлтэй байсан учир, тиймийн тул хаан Зенифтэй хэлэлцээр хийсэн хаан Лемений зальт мөн башир аргад мэхлэгдсэн байв, мөн түүний гарт нутгийн нэг хэсэг эзэмшлийг, бүр Лихай-Нифай хотыг, мөн Шиломын хотыг мөн эргэн тойрны нутгийг алдсан болой—

And now, it came to pass on the morrow that king Limhi sent a proclamation among all his people, that thereby they might gather themselves together to the temple, to hear the words which he should speak unto them.

And it came to pass that when they had gathered themselves together that he spake unto them in this wise, saying: O ye, my people, lift up your heads and be comforted; for behold, the time is at hand, or is not far distant, when we shall no longer be in subjection to our enemies, notwithstanding our many strugglings, which have been in vain; yet I trust there remaineth an effectual struggle to be made.

Therefore, lift up your heads, and rejoice, and put your trust in God, in that God who was the God of Abraham, and Isaac, and Jacob; and also, that God who brought the children of Israel out of the land of Egypt, and caused that they should walk through the Red Sea on dry ground, and fed them with manna that they might not perish in the wilderness; and many more things did he do for them.

And again, that same God has brought our fathers out of the land of Jerusalem, and has kept and preserved his people even until now; and behold, it is because of our iniquities and abominations that he has brought us into bondage.

And ye all are witnesses this day, that Zeniff, who was made king over this people, he being over-zealous to inherit the land of his fathers, therefore being deceived by the cunning and craftiness of king Laman, who having entered into a treaty with king Zeniff, and having yielded up into his hands the possessions of a part of the land, or even the city of Lehi-Nephi, and the city of Shilom; and the land round about—



22 Мөн энэ бүхнийг тэрээр хийсэн нь, энэ хүмүүсийг эрхшээлдээ эсвэл боолчлолд авчрах цорын ганц зорилгын учир болой. Мөн болгоогтун, бид энэ цагт леменчүүдийн хаанд алба гувчуур болгон, өөрсдийн эрдэнэ шишийн тэн хагасыг, мөн өөрсдийн арвайн, мөн бүр өөрсдийн төрөл бүрийн үр тарианы, мөн өөрсдийн бог болон бод малын өссөний нь тэн хагасыг төлдөг; мөн леменчүүдийн хаан түүгээр ч зогсохгүй бидэнд байгаа бүх эзэмшлийн маань тэн хагасыг эсвээс бидний амийг биднээс шаарддаг.

23 Мөн эдүгээ, энэ нь үүрэхэд хүнд бус уу? Мөн бидний энэ зүдгүүр агуу бус уу? Эдүгээ болгоогтун, бидний гашуудах шалтгаан хичнээн агуу билээ.

24 Тийм ээ, би та нарт хэлнэ, бидний гашуудах шалтгаанууд нь агуу болой; учир нь болгоогтун бидний ах дүүсийн хичнээн нь алагдсан билээ, мөн тэдний цус дэмий асгарсан шүү дээ, мөн бүгд алдсын учир болой.

25 Учир нь хэрэв энэ хүмүүс зөрчилд унаагүй сэн бол энэ агуу хилэнц тэдний дээр ирэхийг Их Эзэн хүлцэхгүй байсан буйза. Гэвч болгоогтун, тэд түүний үгсийг сонссон нь үгүй; харин тэдний дунд зөрчилдөөн бий болж, бүр тэд өөрсдийнхөө дунд цус урсгасан нь тийм их байв.

26 Мөн Их Эзэний бошиглогчийг; тийм ээ, Бурханаар сонгогдсон хүнийг, тэдний ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнх нь талаар тэдэнд хэлсэн, мөн болох олон зүйлийг, тийм ээ, бүр Христийн ирэлтийг бошиглосон түүнийг тэд хөнөөсөн юм.

27 Мөн тэрээр тэдэнд Христ бол Бурхан, бүх зүйлийн Эцэг гэдгийг хэлж, мөн тэрээр өөрийн дээр хүний дүрийг авна, мөн энэ нь эхлэлд хүмүүн дууриагдан бүтээгдсэн тэрхүү дүрслэл болохыг хэлсний учир буюу; эсвээс өөр үгээр бол, тэрээр хүмүүн нь Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэнийг хэлж, мөн Бурхан хүмүүний үрсийн дунд доош ирэх ёстой, мөн өөр дээрээ маханбодь болон цусыг авах ёстойг, мөн газрын гадаргуу дээр урагшлан явах ёстойг хэлсэн бөлгөө—

And all this he did, for the sole purpose of bringing this people into subjection or into bondage. And behold, we at this time do pay tribute to the king of the Lamanites, to the amount of one half of our corn, and our barley, and even all our grain of every kind, and one half of the increase of our flocks and our herds; and even one half of all we have or possess the king of the Lamanites doth exact of us, or our lives.

And now, is not this grievous to be borne? And is not this, our affliction, great? Now behold, how great reason we have to mourn.

Yea, I say unto you, great are the reasons which we have to mourn; for behold how many of our brethren have been slain, and their blood has been spilt in vain, and all because of iniquity.

For if this people had not fallen into transgression the Lord would not have suffered that this great evil should come upon them. But behold, they would not hearken unto his words; but there arose contentions among them, even so much that they did shed blood among themselves.

And a prophet of the Lord have they slain; yea, a chosen man of God, who told them of their wickedness and abominations, and prophesied of many things which are to come, yea, even the coming of Christ.

And because he said unto them that Christ was the God, the Father of all things, and said that he should take upon him the image of man, and it should be the image after which man was created in the beginning; or in other words, he said that man was created after the image of God, and that God should come down among the children of men, and take upon him flesh and blood, and go forth upon the face of the earth—

- 28 Мөн эдүгээ, тэрээр үүнийг хэлсэн учир, тэд түүнийг үхэлд хүргэжээ; мөн тэд Бурханы хилэнг доош өөрсдийн дээр авчрах өөр олон зүйлийг үйлдсэн билээ. Тиймийн тул, тэд боолчлолд байгаад, мөн тэд зовлонг зүдгүүрүүдээр цохигдсонд хэн гайхширах билээ
- 29 Учир нь болгоогтун, Их Эзэн хэлсэн нь: зөрчлийнхээ өдөрт буй өөрийн хүмүүсийг би халамжлахгүй; харин тэд хөгжин дэвшихгүйн тулд тэдний замд би саад тавих болно; мөн тэдний үйлүүд өөрсдийнх өмнө тээглэх чулуу лугаа адил байх болно.
- 30 Мөн түүнчлэн тэрээр хэлэх: Хэрэв миний хүмүүс бузрыг тарих аваас түүнийхээ хаягдлыг салхин хүрдэнд хурааж авах болно; мөн үүний үр дүн нь хор байх буюу.
- 31 Мөн түүнчлэн тэрээр хэлэв: Хэрэв миний хүмүүс бузрыг тарих аваас устгалыг даруй авчрагч дорнын салхийг хураан авах болно.
- 32 Мөн эдүгээ, болгоогтун, Их Эзэний амлалт биелсэн, мөн та нар цохигдсон бас зовоогдсон болой.
- 33 Гэвч хэрэв та нар зүрх сэтгэлийн дүүрэн зорилготойгоор Их Эзэнд хандвал, мөн найдвараа түүнд өгвөл, мөн оюуныхаа бүх чармайлтаар түүнд үйлчилбэл, хэрэв та нар үүнийг хийвэл, тэрээр таалал мөн хүслийнхээ дагуу, та нарыг боолчлолоос гарган чөлөөлөх болно.

And now, because he said this, they did put him to death; and many more things did they do which brought down the wrath of God upon them. Therefore, who wondereth that they are in bondage, and that they are smitten with sore afflictions?

For behold, the Lord hath said: I will not succor my people in the day of their transgression; but I will hedge up their ways that they prosper not; and their doings shall be as a stumbling block before them.

And again, he saith: If my people shall sow filthiness they shall reap the chaff thereof in the whirlwind; and the effect thereof is poison.

And again he saith: If my people shall sow filthiness they shall reap the east wind, which bringeth immediate destruction.

And now, behold, the promise of the Lord is fulfilled, and ye are smitten and afflicted.

But if ye will turn to the Lord with full purpose of heart, and put your trust in him, and serve him with all diligence of mind, if ye do this, he will, according to his own will and pleasure, deliver you out of bondage.

## Мозая 8

- 1 Мөнхүү улиран тохиох дор хаан Лимхай өөрийн хүмүүст ярьснаа төгсгөл болгосны дараа, учир нь тэрээр тэдэнд олон зүйлийг ярьсан мөн зөвхөн тэдгээрийн цөөнийг нь би энэ номонд бичиглэснийг, тэрээр Зарахемлагийн нутагт байсан ах дүүсийнхээ талаар бүх зүйлийг өөрийн хүмүүст ярьсан болно.
- 2 Мөн тэрээр Аммоныг олон түмний өмнө босгож, мөн тэдэнд Зениф уг нутгаас гарсан тэр цагаас бүр тэр өөрөө уг нутгаас гарч ирэх тэр цагийг хүртэл тэдний ах дүүст тохиолдсон бүгдийг тоочихоор болгов.
- 3 Мөн тэрээр түүнчлэн хаан Бенжамины тэдэнд заасан эцсийн үгсийг тэдэнд давтан хэлж, мөн хаан Лимхайн хүмүүст тэд түүний ярьсан бүх үгийг ойлгож болохын тулд тэдгээрийг тайлбарлав.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэрээр энэ бүгдийг хийсний дараа, хаан Лимхай олон түмнийг тарааж, мөн тэд хүн бүрийг гэртээ эргэж очих болгов.
- 5 Мөнхүү улиран тохиох дор тэрээр, тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас түүний хүмүүсийн цэдгийг тээсэн ялтсуудыг, тэрээр тэдгээрийг уншиж болохын тулд Аммоны өмнө авчрагдахаар болгов.
- 6 Эдүгээ, Аммон уг ялтсыг уншмагц, тэрээр хэлийг хөрвүүлж чадах эсэхийг мэдэхээр хаан түүнээс асуув, мөн Аммон чадахгүйгээ түүнд хэлэв.
- 7 Мөн хаан түүнд хэлэв: өөрийн хүмүүсийн зовлон зүдгүүрийн төлөө би гашуудсан учир, тэд Зарахемлагийн нутгийг олж болохын тулд, биднийг боолчлолоос чөлөөлөхийг бид гуйж болохын тулд, ах дүүсээсээ би өөрийн хүмүүсээс дөчин гурвыг аглаг буйдад замд гаргасан билээ.
- 8 Мөн тэд аглаг буйдад олон өдрийн турш төөрчээ, гэвч тэд шаргуу байсан аж, гэвч Зарахемлагийн нутгийг олсонгүй, харин их усны дундах нутагт аялсны дараа, хүний мөн амьтны ясаар хучигдсан, мөн түүнчлэн янз бүрийн барилгуудын балгасуудаар дүүрсэн нэгэн нутагт очсоны дараа, Израилын олны адил тоолшгүй байсан хүмүүсээр эзэгнэгдэж асан нутгийг олж мэдсэнийхээ дараа харин энэ нутагтаа эргэж иржээ.

## Mosiah 8

And it came to pass that after king Limhi had made an end of speaking to his people, for he spake many things unto them and only a few of them have I written in this book, he told his people all the things concerning their brethren who were in the land of Zarahemla.

And he caused that Ammon should stand up before the multitude, and rehearse unto them all that had happened unto their brethren from the time that Zeniff went up out of the land even until the time that he himself came up out of the land.

And he also rehearsed unto them the last words which king Benjamin had taught them, and explained them to the people of king Limhi, so that they might understand all the words which he spake.

And it came to pass that after he had done all this, that king Limhi dismissed the multitude, and caused that they should return every one unto his own house.

And it came to pass that he caused that the plates which contained the record of his people from the time that they left the land of Zarahemla, should be brought before Ammon, that he might read them.

Now, as soon as Ammon had read the record, the king inquired of him to know if he could interpret languages, and Ammon told him that he could not.

And the king said unto him: Being grieved for the afflictions of my people, I caused that forty and three of my people should take a journey into the wilderness, that thereby they might find the land of Zarahemla, that we might appeal unto our brethren to deliver us out of bondage.

And they were lost in the wilderness for the space of many days, yet they were diligent, and found not the land of Zarahemla but returned to this land, having traveled in a land among many waters, having discovered a land which was covered with bones of men, and of beasts, and was also covered with ruins of buildings of every kind, having discovered a land which had been peopled with a people who were as numerous as the hosts of Israel.

- 9 Мөн тэд хэлсэн зүйлүүдийнхээ үнэний гэрчлэл болгон сийлбэрээр дүүрэн, мөн цэвэр алт болох хорин дөрвөн ялтсыг авчирсан болой.
- 10 Мөн болгоогтун, түүнчлэн, тэд том, мөн гууль мөн зэсэн, мөн бүх талаараа төгс сайн цээжний хуягуудыг авчирсан бөлгөө.
- 11 Мөн түүнчлэн, тэд илднүүдийг авчрав, тэдгээрийн бариулууд нь өгөр даасан, мөн ирт хэсгүүд нь зэвэнд идэгдсэн байв; мөн ялтсууд дээрх сийлбэрүүд эсвэл уг хэлийг хөрвүүлж чадах хэн ч энэ нутагт байсангүй. Тиймийн тул би танд хэлсэн билээ: Та орчуулж чадах сан болов уу
- 12 Мөн би танд дахин хэлье: Та орчуулж чадах хэн нэгнийг мэдэх сэн болов уу? Учир нь би эдгээр цэдгүүд бидний хэлэнд орчуулагдахыг хүснэ; учир нь магадгүй, эдгээр ялтсууд ирсэн тэнд байсан эдгээр нь устгагдсан хүмүүсийн үлдэгдлийн тухай мэдлэгийг бидэнд өгөх болно; эсвээс, магадгүй, тэдгээр нь чухам устгагдсан тэр хүмүүсийн тухай мэдлэгийг бидэнд өгөх болно; мөн би тэдний устгалын шалтгааныг мэдэх хүсэлтэй байна.
- 13 Эдүгээ Аммон түүнд хэлэв: Ай хаантан, уг цэдгүүдийг орчуулж чадах хүний тухайд би танд лавтайяа хэлж чадна; учир нь эрт цагийн бүх цэдгүүдийг үзэж, мөн орчуулж чадах ямар нэгэн зүйл түүнд буй; мөн энэ нь Бурханы бэлэг юм. Мөн уг зүйлүүд хөрвүүлэгч гэж нэрлэгддэг, мөн зарлигдуулахаас бусдаар бол түүгээр нэг ч хүн харж чадахгүй, харах учиргүй зүйлийг тэрээр хайж мөн тэрээр мөхөх болуузай. Мөн түүгээр харахыг зарлигдуулсан нь, мөнхүү тэр нь үзмэрч хэмээн нэрлэгддэг болой.
- 14 Мөн болгоогтун, Зарахемла нутаг дахь тэр хүмүүсийн хаан бол эдгээр зүйлийг хийхээр зарлигдуулсан, мөн Бурханаас энэ өндөр бэлгийг хүртсэн хүн юм.
- 15 Мөн үзмэрч нь бошиглогчоос агуу гэж хаан хэлэв.

And for a testimony that the things that they had said are true they have brought twenty-four plates which are filled with engravings, and they are of pure gold.

And behold, also, they have brought breastplates, which are large, and they are of brass and of copper, and are perfectly sound.

And again, they have brought swords, the hilts thereof have perished, and the blades thereof were cankered with rust; and there is no one in the land that is able to interpret the language or the engravings that are on the plates. Therefore I said unto thee: Canst thou translate?

And I say unto thee again: Knowest thou of any one that can translate? For I am desirous that these records should be translated into our language; for, perhaps, they will give us a knowledge of a remnant of the people who have been destroyed, from whence these records came; or, perhaps, they will give us a knowledge of this very people who have been destroyed; and I am desirous to know the cause of their destruction.

Now Ammon said unto him: I can assuredly tell thee, O king, of a man that can translate the records; for he has wherewith that he can look, and translate all records that are of ancient date; and it is a gift from God. And the things are called interpreters, and no man can look in them except he be commanded, lest he should look for that he ought not and he should perish. And whosoever is commanded to look in them, the same is called seer.

And behold, the king of the people who are in the land of Zarahemla is the man that is commanded to do these things, and who has this high gift from God.

And the king said that a seer is greater than a prophet.

16 Мөн Аммон хэлэхдээ үзмэрч мөн илчлэгч мөн түүнчлэн бошиглогч; мөн хэний ч агуулж үл чадах Бурханы тэрхүү хүчийг агуулснаас бусдаар бол, хэн ч үүнээс илүү агуу бэлгийг хүртэж чадахгүй; гэсэн хэдий ч хүмүүнд агуу их хүч Бурханаас өгөгдөж болох бөлгөө.

17 Харин үзмэрч өнгөрсөн зүйлийг, мөн түүнчлэн ирэх зүйлийг мэдэж чадна, мөн тэдгээр бүх зүйл илчлэгдэх болно, эсвээс, чухамдаа, нууц зүйлүүд үзүүлэгдэх болно, мөн далдлагдсан зүйлүүд гэрэлд гарч ирэх болно, мөн мэдэгдээгүй зүйлүүд тэднээр мэдэгдэх болно, мөн түүнчлэн өөр нөхцөлд мэдэгдэж болох зүйлүүд тэднээр мэдэгдэх буюу.

18 Тийн хүмүүн итгэлээрээ дамжуулан, агуу гайхамшгуудыг хийж болох нэгэн аргаар Бурхан хангажээ; тиймийн тул тэрээр бусдадаа агуу ашиг тус хүргэх бөлгөө.

19 Мөн эдүгээ, Аммон эдгээр үгсийг ярихаа төгсгөл болгоход хаан үлэмж баясан, мөн Бурханд талархал илэрхийлж, хэлсэн нь: Эргэлзээгүйгээр нэгэн агуу нууц эдгээр ялтсуудад тээгдсэн буй, мөн эдгээр хөрвүүлэгчид эргэлзээгүйгээр бүх тийм нууцуудыг хүмүүний үрсэд мэдүүлэх зорилгын тулд бэлтгэгдсэн буйза.

20 Ай Их Эзэний ажлууд хичнээн гайхамшигтай билээ, мөн өөрийн хүмүүсийг тэрээр хичнээн удаан тэсвэрлэдэг билээ; тийм ээ, хүмүүний үрсийн ойлголт ямар харалган мөн нэвтэршгүй билээ; учир нь тэд мэргэн ухааныг хайх нь үгүй, мөн тэрнийг өөрсдийн дээр захируулах хүсэл ч үгүй болой!

21 Тийм ээ, тэд хоньчноос зугтан мөн бутарч, мөн зайлан холдож, мөн ойн зэрлэг араатнаар цөлмүүлэх зэрлэг сүрэг лугаа адил болой.

And Ammon said that a seer is a revelator and a prophet also; and a gift which is greater can no man have, except he should possess the power of God, which no man can; yet a man may have great power given him from God.

But a seer can know of things which are past, and also of things which are to come, and by them shall all things be revealed, or, rather, shall secret things be made manifest, and hidden things shall come to light, and things which are not known shall be made known by them, and also things shall be made known by them which otherwise could not be known.

Thus God has provided a means that man, through faith, might work mighty miracles; therefore he becometh a great benefit to his fellow beings.

And now, when Ammon had made an end of speaking these words the king rejoiced exceedingly, and gave thanks to God, saying: Doubtless a great mystery is contained within these plates, and these interpreters were doubtless prepared for the purpose of unfolding all such mysteries to the children of men.

O how marvelous are the works of the Lord, and how long doth he suffer with his people; yea, and how blind and impenetrable are the understandings of the children of men; for they will not seek wisdom, neither do they desire that she should rule over them!

Yea, they are as a wild flock which fleeth from the shepherd, and scattereth, and are driven, and are devoured by the beasts of the forest.

*Зениффийн цэдэг—тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас хойш тэд леменчүүдийн гараас чөлөөлөгдсөн цагийг хүртэлх түүний хүмүүсийн шастир оршвой.*

## Мозая 9

- 1 Би, Зениф, нифайчуудын бүх хэлийг заалгасан тул, мөн Нифайн нутгийн, өөрөөр хэлбэл өөрийн эцэг өвгөдийн анхны өвлүүлсэн нутгийн мэдлэгтэй байсан учир, мөн леменчүүдийн дунд манай их цэрэг тэдний дээр ирж мөн тэднийг устгаж болохын тулд би тэдний хүчийг тагнаж болно хэмээн туршуулаар илгээгдсэн учир—гэвч би тэдний дунд сайн нь байгааг хараад тэд устгагдахгүй байж болно хэмээх хүсэлтэй байсан болой би.
- 2 Тиймийн тул, бидний захирагч тэдэнтэй хэлэлцээр хийгээсэй хэмээсэн учир аглаг буйдад би ах дүүстэйгээ маргав; гэвч тэрээр догшин мөн цусанд дуртай хүн байсан учир намайг алагдвал зохино хэмээн зарлигдав; харин их цус урсгасны дүнд би амь гарсан бөлгөө; учир нь эцэг хүн эцэг хүний эсрэг, мөн ах нь дүүгийнхээ эсрэг, аглаг буйд дахь манай их цэргийн ихэнх нь устгагдтал тулалдав; мөн бид амьд үлдсэн тэд Зарахемлагийн нутаг тийш өөрсдийн эхнэр мөн хүүхдүүдэд болсон явдлыг хэлэхээр эргэж ирсэн бөлгөө.
- 3 Гэсэн хэдий ч, би эцэг өвгөдийнхөө нутгийг өвлөх дэндүү их хүсэлтэй байсан учир, уг нутгийг эзэмшихээр явах хүсэлтэй байсан олныг цуглуулж, мөн уг нутагт очихоор дахин аглаг буйд дахь аянаа эхэлсэн буюу; гэвч бид өлсгөлөн мөн зовлонг зүдгүүрүүдэд цохигдсон болой; учир нь бид Их Эзэн Бурханаа санахдаа хойрго байв.
- 4 Гэсэн хэдий ч, олон өдөр аглаг буйдад бэдэрсний эцэст бид эцэг өвгөдийн минь нутгийн ойролцоо байсан, ах дүүсийнхээ алагдсан тэр газар майхнуудаа босгов.
- 5 Мөнхүү улиран тохиох дор би хааны санаа бодлыг мэдэж болохын тулд, мөн өөрийн хүмүүстэй очиж мөн нутгийг амгалан эзэмшиж болох эсэхийг мэдэж болохын тулд, би дөрвөн хүнийхээ хамт дахин хотод орж хаан дээр очив.

*THE RECORD OF ZENIFF—An account of his people, from the time they left the land of Zarahemla until the time that they were delivered out of the hands of the Lamanites.*

## Mosiah 9

I, Zeniff, having been taught in all the language of the Nephites, and having had a knowledge of the land of Nephi, or of the land of our fathers' first inheritance, and having been sent as a spy among the Lamanites that I might spy out their forces, that our army might come upon them and destroy them—but when I saw that which was good among them I was desirous that they should not be destroyed.

Therefore, I contended with my brethren in the wilderness, for I would that our ruler should make a treaty with them; but he being an austere and a blood-thirsty man commanded that I should be slain; but I was rescued by the shedding of much blood; for father fought against father, and brother against brother, until the greater number of our army was destroyed in the wilderness; and we returned, those of us that were spared, to the land of Zarahemla, to relate that tale to their wives and their children.

And yet, I being over-zealous to inherit the land of our fathers, collected as many as were desirous to go up to possess the land, and started again on our journey into the wilderness to go up to the land; but we were smitten with famine and sore afflictions; for we were slow to remember the Lord our God.

Nevertheless, after many days' wandering in the wilderness we pitched our tents in the place where our brethren were slain, which was near to the land of our fathers.

And it came to pass that I went again with four of my men into the city, in unto the king, that I might know of the disposition of the king, and that I might know if I might go in with my people and possess the land in peace.

- 6 Мөн би хаан дээр очиж, мөн тэрээр надтай бибээр Лихай-Нифайн нутгийг мөн Шиломын нутгийг эзэмшиж болохоор гэрээлсэн болой.
- 7 Мөн түүнчлэн тэрээр өөрийн хүмүүсийг уг нутгаас гарахыг зарлиглаж, мөн би болон миний хүмүүс бид үүнийг эзэмшиж болохын тулд уг нутагт очсон бөлгөө.
- 8 Мөн бид барилгууд барьж, мөн хотын хэрмийг, тийм ээ, бүр Лихай-Нифай хотын мөн Шилом хотын хэрмийг засч эхлэв.
- 9 Мөн бид газар боловсруулж, тийм ээ, бүр бүх төрлийн үрээр, эрдэнэ шишийн үрээр, мөн буудай, мөн арвай, мөн нис, мөн шимийн, мөн янз бүрийн жимсний үрээр буюу; мөн бид өнөржин мөн уг нутагт дэгжиж эхэлсэн бөлгөө.
- 10 Эдүгээ бид үүнийг эзэмшиж болохын тулд уг нутгийг тэрээр өгсөн нь миний хүмүүсийг боолчлолд авчрах хаан Лемений заль бас башир арга байжээ.
- 11 Тиймийн тул улиран тохиох дор, бид уг нутагт арванхоёр жил оршсоны дараа, миний хүмүүс уг нутагт хүчирхэгжиж мөн тэд тэднийг хүчээр давамгайлж мөн тэднийг боолчлолд оруулж чадахгүй болуузай хэмээн айх учир хаан Лемэн эмээж эхлэв.
- 12 Эдүгээ тэд залхуу мөн хиймэл шүтээн шүтэгч хүмүүс байв; тиймийн тул тэд бидний гарын хөдөлмөрөөр өөрсдийгөө цатгаж болохын тулд, тийм ээ, тэд бэлчээр дэх сүргийн маань дээр өөрсдөө зооглож болохын тулд буюу тэд биднийг боолчлолд оруулах хүсэлтэй байлаа.
- 13 Тиймийн тул улиран тохиох дор тэднийг миний хүмүүстэй маргаж тэмцэлдүүлэхийн тулд хаан Лемэн хүмүүсээ өдөөн хатгаж эхлэв; тиймийн тул уг нутагт дайнууд мөн зөрчилдөөн байж эхлэв.
- 14 Учир нь, Нифайн нутагт, Шиломын нутгийн өмнөдөд миний засаглалын арвангурав дахь жилд, миний хүмүүс сүргээ усалж мөн тэжээж, мөн газраа боловсруулж байх үед олон тооны лемэнчүүд тэдэн дээр ирж мөн тэднийг хөнөөж, мөн тэдний сүргийг, мөн тэдний талбай дахь эрдэнэ шишийг олзлон авч эхэллээ.
- 15 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор тэд зугтаж, бүр Нифайн хотод ортлоо, гүйцэгдээгүй бүгд нь, мөн надаас өмгөөлөл хүсэн дуудав.

And I went in unto the king, and he covenanted with me that I might possess the land of Lehi-Nephi, and the land of Shilom.

And he also commanded that his people should depart out of the land, and I and my people went into the land that we might possess it.

And we began to build buildings, and to repair the walls of the city, yea, even the walls of the city of Lehi-Nephi, and the city of Shilom.

And we began to till the ground, yea, even with all manner of seeds, with seeds of corn, and of wheat, and of barley, and with neas, and with sheum, and with seeds of all manner of fruits; and we did begin to multiply and prosper in the land.

Now it was the cunning and the craftiness of king Laman, to bring my people into bondage, that he yielded up the land that we might possess it.

Therefore it came to pass, that after we had dwelt in the land for the space of twelve years that king Laman began to grow uneasy, lest by any means my people should wax strong in the land, and that they could not overpower them and bring them into bondage.

Now they were a lazy and an idolatrous people; therefore they were desirous to bring us into bondage, that they might glut themselves with the labors of our hands; yea, that they might feast themselves upon the flocks of our fields.

Therefore it came to pass that king Laman began to stir up his people that they should contend with my people; therefore there began to be wars and contentions in the land.

For, in the thirteenth year of my reign in the land of Nephi, away on the south of the land of Shilom, when my people were watering and feeding their flocks, and tilling their lands, a numerous host of Lamanites came upon them and began to slay them, and to take off their flocks, and the corn of their fields.

Yea, and it came to pass that they fled, all that were not overtaken, even into the city of Nephi, and did call upon me for protection.

- 16 Мөнхүү улиран тохиох дор би тэднийг нум, мөн сум, илд мөн сэлэм, мөн бороохой, мөн дүүгүүрүүдээр, мөн бид бүтээж чадах л бүх төрлийн зэвсгүүдээр зэвсэглэн, мөн би болон миний хүмүүс леменчүүдийн эсрэг тулалдахаар давшсан билээ.
- 17 Тийм ээ, Их Эзэний хүчинд бид леменчүүдийн эсрэг тулалдахаар давшин явав; учир нь би болон миний хүмүүс, тэрээр биднийг дайснуудын маань гараас чөлөөлөөсэй хэмээн Их Эзэнд хүчтэйгээр гуйн залбирсан болой, учир нь бид эцэг өвгөдийнхөө чөлөөлөлтийн тухай дурсамжинд сэрээгдсэн болой.
- 18 Мөн Бурхан бидний гуйлтыг анлааран сонсож, мөн бидний залбирлуудад хариулсан билээ; мөн бид түүний хүчинд урагш давшив; тийм ээ, бид леменчүүдийн эсрэг урагш давшиж, мөн нэг өдөр мөн нэг шөнийн дотор бид гурван мянга дөчин гурвыг хөнөөв; бид тэднийг бүр нутгаасаа зайлуулан гаргатал хөнөөсөн бөлгөө.
- 19 Мөн би, өөрөө, өөрийн гараар, тэдний үхэгсдийг оршуулахад туслав. Мөн болгоогтун, бидний агуу харамсал мөн гашуудал болж, ах дүүсийн маань хоёр зуун далан ес нь алагдсан байв.

And it came to pass that I did arm them with bows, and with arrows, with swords, and with cimeters, and with clubs, and with slings, and with all manner of weapons which we could invent, and I and my people did go forth against the Lamanites to battle.

Yea, in the strength of the Lord did we go forth to battle against the Lamanites; for I and my people did cry mightily to the Lord that he would deliver us out of the hands of our enemies, for we were awakened to a remembrance of the deliverance of our fathers.

And God did hear our cries and did answer our prayers; and we did go forth in his might; yea, we did go forth against the Lamanites, and in one day and a night we did slay three thousand and forty-three; we did slay them even until we had driven them out of our land.

And I, myself, with mine own hands, did help to bury their dead. And behold, to our great sorrow and lamentation, two hundred and seventy-nine of our brethren were slain.



## Мозая 10

- 1 Мөнхүү улиран тохиох дор бид хаант улсыг дахин тохинуулж эхлэн мөн бид уг нутгийг дахин энх амгалан байдалд эзэмшиж эхлэв. Мөн леменчүүд миний хүмүүсийн эсрэг дайтахаар ирэх тэр цагт өөрийн хүмүүст зориулах зэр зэвсгүүд надад байж болохын тулд би дайны төрөл бүрийн зэвсгүүд хийгдэхээр болгов.
- 2 Мөн леменчүүд санамсаргүй байхад маань бидний дээр дахин ирж мөн биднийг устгаж чадахгүйн тулд би нутгийн эргэн тойронд харуулууд гаргав; мөн тийн би хүмүүсээ мөн мал сүргээ харгалзаж, мөн тэднийг дайснуудынхаа гарт орохоос хамгаалж байв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор эцэг өвгөдийн нутгийг бид олон жил, тийм ээ, хорин хоёр жилийн турш өвлөн суув.
- 4 Мөн би эрчүүдийг газар боловсруулан, мөн бүх төрлийн тариа мөн янз бүрийн жимсний бүх төрлийг ургуулах болгосон билээ.
- 5 Мөн бид нүцгэнээ хувцаслаж болохын тулд эмэгтэйчүүдийг утас ээрэх, нөр хөдөлмөрлөх хийгээд ажиллах, мөн бүх төрлийн нарийн нэхээст эд хийх, тийм ээ, мөн төрөл бүрийн даавуу хийхээр болгосон билээ би; мөн ийн бид уг нутагт дэгжив—ийн бид уг нутагт хорин хоёр жилийн турш үргэлжийн энх амгалан байв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор хаан Лемен насан эцэслэв, мөн түүний оронд хүү нь засаглаж эхлэв. Мөн тэрээр өөрийн хүмүүсийг миний хүмүүсийн эсрэг эсэргүүцэлд өдөөн хатгав; тиймийн тул тэд дайнд бэлтгэж, мөн миний хүмүүсийн эсрэг тулалдахаар ирж эхлэв.
- 7 Гэвч би тэдний бэлтгэлийг олж мэдэж болохын тулд, тэд миний хүмүүс дээр ирж мөн тэднийг устгаж болзошгүйн учир, би тэдний эсрэг хамгаалж болно хэмээн туршуулуудаа Шимлон нутгийн эргэн тойронд илгээсэн болой.

## Mosiah 10

And it came to pass that we again began to establish the kingdom and we again began to possess the land in peace. And I caused that there should be weapons of war made of every kind, that thereby I might have weapons for my people against the time the Lamanites should come up again to war against my people.

And I set guards round about the land, that the Lamanites might not come upon us again unawares and destroy us; and thus I did guard my people and my flocks, and keep them from falling into the hands of our enemies.

And it came to pass that we did inherit the land of our fathers for many years, yea, for the space of twenty and two years.

And I did cause that the men should till the ground, and raise all manner of grain and all manner of fruit of every kind.

And I did cause that the women should spin, and toil, and work, and work all manner of fine linen, yea, and cloth of every kind, that we might clothe our nakedness; and thus we did prosper in the land—thus we did have continual peace in the land for the space of twenty and two years.

And it came to pass that king Laman died, and his son began to reign in his stead. And he began to stir his people up in rebellion against my people; therefore they began to prepare for war, and to come up to battle against my people.

But I had sent my spies out round about the land of Shemlon, that I might discover their preparations, that I might guard against them, that they might not come upon my people and destroy them.

- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд Шилом нутгийн умардад, олон тооны хүмүүстэйгээ, эрчүүд нь нумаар, мөн сумаар, мөн сэлмээр, мөн илдээр, мөн чулуу, мөн дүүгүүрүүдээр зэвсэглэн ирэв; мөн тэд үсээ хусуулсан учир толгой нүцгэн байв; мөн тэд хэвлийн тус газартаа ширэн халхавч бүсэлжээ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор би хүмүүсийнхээ эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг нь аглаг буйдад нуугдахаар болгов; мөн түүнчлэн зэвсэг хэрэглэж чадах өөрийн бүх настай эрчүүдийг, мөн түүнчлэн зэвсэг хэрэглэх боломжтой бүх залуу эрчүүдээ, леменчүүдийн эсрэг тулалдахаар нэгдэн цугларахаар болгов би; мөн би тэднийг насных нь дагуу хүн бүрийг эрэмбэлэн эгнээнд нь байрлуулсан бөлгөө.
- 10 Мөнхүү улиран тохиох дор бид леменчүүдийн эсрэг тулалдахаар явав; мөн би, бүр би хүртэл, өтөл насандаа, леменчүүдийн эсрэг тулалдахаар явав. Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний хүчинд бид тулалдахаар явсан болой.
- 11 Эдүгээ, леменчүүд Их Эзэний талаар, бас Их Эзэний хүчний талаар юу ч эс мэддэг, тиймийн тул тэд өөрсдийн хүчинд тулгуурлаж байв. Гэсэн ч тэд хүмүүний хүч чадлын хувьд хүчирхэг хүмүүс байлаа.
- 12 Тэд зэрлэг, мөн догшин ширүүн, мөн цусанд шунасан хүмүүс, эцэг өвгөдийнхөө заншилд итгэдэг байв, тэр нь—тэд эцэг өвгөд нь алдсуудын учир Иерусалим нутгаас хөөгдөн гарсан гэдэгт, мөн тэд аглаг буйдад өөрсдийн ах дүүсээр шударга бусаар сүйтгэгдсэн, мөн тэд түүнчлэн далай гатлах үедээ шударга бусаар сүйтгэгдсэн гэдэгт итгэдэг байсан бөлгөө;
- 13 Мөн түүнчлэн, тэд далайг гаталсны дараа анхны өвийн нутагтаа байх зуур тэд сүйтгэгдсэн гэдэгт, мөн энэ бүгд Нифай Их Эзэний зарлигуудыг дагахдаа илүү итгэлтэй байсны учир—тиймийн тул тэрээр Их Эзэнээр өндөр их ээл хишиг хүртээгдсэн аж, учир нь Их Эзэн түүний залбирлуудыг анхааран сонсож мөн тэдгээрт хариулсан байв, мөн тэрээр аглаг буйд дахь аяныхаа удирдлагыг авчээ.
- 14 Мөн түүний ах нар Их Эзэний үйл хэргүүдийг үл ойлгохын учир түүнд хилэгнэж байсан ажээ; тэд түүнчлэн Их Эзэний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулсаны учир их усан дээр түүнд тэд хилэгнэсэн бөлгөө.

And it came to pass that they came up upon the north of the land of Shilom, with their numerous hosts, men armed with bows, and with arrows, and with swords, and with cimeters, and with stones, and with slings; and they had their heads shaved that they were naked; and they were girded with a leathern girdle about their loins.

And it came to pass that I caused that the women and children of my people should be hid in the wilderness; and I also caused that all my old men that could bear arms, and also all my young men that were able to bear arms, should gather themselves together to go to battle against the Lamanites; and I did place them in their ranks, every man according to his age.

And it came to pass that we did go up to battle against the Lamanites; and I, even I, in my old age, did go up to battle against the Lamanites. And it came to pass that we did go up in the strength of the Lord to battle.

Now, the Lamanites knew nothing concerning the Lord, nor the strength of the Lord, therefore they depended upon their own strength. Yet they were a strong people, as to the strength of men.

They were a wild, and ferocious, and a blood-thirsty people, believing in the tradition of their fathers, which is this—Believing that they were driven out of the land of Jerusalem because of the iniquities of their fathers, and that they were wronged in the wilderness by their brethren, and they were also wronged while crossing the sea;

And again, that they were wronged while in the land of their first inheritance, after they had crossed the sea, and all this because that Nephi was more faithful in keeping the commandments of the Lord—therefore he was favored of the Lord, for the Lord heard his prayers and answered them, and he took the lead of their journey in the wilderness.

And his brethren were wroth with him because they understood not the dealings of the Lord; they were also wroth with him upon the waters because they hardened their hearts against the Lord.

15 Мөн түүнчлэн, тэд амлагдсан нутагт хүрч ирэхдээ, тэд хүмүүсийг удирдах эрхийг тэдний гараас тэрээр булаан авсан хэмээсний учир тэд түүнд хилэгнэсэн аж; мөн тэд түүнийг егүүтэхийг эрэлхийлсэн болой.

16 Мөн түүнчлэн, тэрээр Их Эзэн түүнд зарлигласны дагуу аглаг буйдад одож мөн гуулин ялтсууд дээр сийлбэрлэгдсэн цэдгүүдийг авсан учир тэд түүнд хилэгнэсэн аж, учир нь тэрээр тэднийг дээрэмдсэн хэмээн тэд хэлжээ.

17 Мөн тийн тэд хүүхдүүддээ тэд тэднийг үзэн ядах, мөн тэд тэднийг алан хядаж, мөн тэд тэднийг дээрэмдэн мөн тэднийг тонох, мөн тэд бүгд тэднийг устгахын тулд чадах бүхнээ хийвэл зохино хэмээн сургацаар ирсэн билээ; тиймийн тул тэд Нифайн үрсийн талаар мөнхийн үзэн ядалтыг агуулдаг.

18 Чухам энэхүү шалтгааны учир хаан Лемен өөрийн заль мэх, мөн хуурамч башир арга, мөн сайхан амлалтуудаараа намайг залилсан юм, иймээс тэд тэднийг устгаж болохын улмаас билээ, би өөрийн энэ хүмүүсийг энэ нутагт авчирсан; тийм ээ, мөн бид энэ олон жилийг уг нутагт зовж өнгөрөөв.

19 Мөн эдүгээ би, Зениф, леменчүүдийн талаар эдгээр бүх зүйлийг өөрийн хүмүүст хэлсний дараа, би тэднийг өөрсдийн хүчээр, Их Эзэнд найдлагаа тавин, тулалдахаар явахыг тэдэнд уриалав; тиймийн тул, бид тэдэнтэй нүүр тулан тэмцэлдэв.

20 Мөнхүү улиран тохиох дор бид тэднийг нутгаасаа дахин гаргав; мөн бид тэднийг хөнөөсөн нь асар их аллага болж, бүр бид тэднийг тоолшгүй тийм олон байсан бөлгөө.

21 Мөнхүү улиран тохиох дор бид нутагтаа эргэж ирэв, мөн миний хүмүүс дахин мал сүргээ адуулж, мөн газраа боловсруулж эхлэв.

22 Мөн эдүгээ би, өтөлсний учир, хөвгүүдийнхээ нэгэнд хаант улсыг шилжүүлэн өгөв; тиймийн тул, би өөрийг үл хэлнэ, мөн Их Эзэн миний хүмүүсийг адислах болтугай. Амен.

And again, they were wroth with him when they had arrived in the promised land, because they said that he had taken the ruling of the people out of their hands; and they sought to kill him.

And again, they were wroth with him because he departed into the wilderness as the Lord had commanded him, and took the records which were engraven on the plates of brass, for they said that he robbed them.

And thus they have taught their children that they should hate them, and that they should murder them, and that they should rob and plunder them, and do all they could to destroy them; therefore they have an eternal hatred towards the children of Nephi.

For this very cause has king Laman, by his cunning, and lying craftiness, and his fair promises, deceived me, that I have brought this my people up into this land, that they may destroy them; yea, and we have suffered these many years in the land.

And now I, Zeniff, after having told all these things unto my people concerning the Lamanites, I did stimulate them to go to battle with their might, putting their trust in the Lord; therefore, we did contend with them, face to face.

And it came to pass that we did drive them again out of our land; and we slew them with a great slaughter, even so many that we did not number them.

And it came to pass that we returned again to our own land, and my people again began to tend their flocks, and to till their ground.

And now I, being old, did confer the kingdom upon one of my sons; therefore, I say no more. And may the Lord bless my people. Amen.

## Мозая 11

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Зениф хаант улсыг хөвгүүдийнхээ нэг болох Ноад шилжүүлэв; тиймийн тул Ноа түүний оронд засаглаж эхлэв; мөн тэрээр эцгийнхээ замуудаар алхсан нь үгүй.
- 2 Учир нь болгоогтун, тэрээр Бурханы зарлигуудыг дагасангүй, харин тэр зүрх сэтгэлийнхээ хүслийн дагуу алхсан болой. Мөн тэрээр олон эхнэр мөн татвар эмстэй байв. Мөн тэр өөрийн хүмүүсийг нүгэл үйлдэж мөн Их Эзэний мэлмийд жигшүүрт болох тэрийг үйлдэх болгов. Тийм ээ, мөн тэд садар самууныг мөн бүх төрлийн ёс бусыг үйлдсэн болой.
- 3 Мөн тэрээр тэдний эзэмшсэн бүгдийн тавны нэгийг, алтных нь мөн мөнгөнийх нь тавны нэгийг, мөн зифийнх нь, мөн тэдний зэс, гууль мөн тэдний төмрийнх нь тавны нэгийг, мөн төл малынх нь тавны нэгийг; мөн түүнчлэн тэдний бүх үр тарианы тавны нэгийг татвар болгон тогтоов.
- 4 Мөн энэ бүгдийг тэр өөрийгөө, мөн эхнэрүүдээ мөн татвар эмсээ, мөн түүнчлэн санваартнуудаа, мөн тэдний эхнэрүүд мөн тэдний татвар эмсийг тэтгэхээр авчээ; тийн тэрээр хаант улсын хэргийг өөрчлөв.
- 5 Учир нь тэрээр түүний эцгээр адислан томилогдсон бүх санваартнуудыг буулгаж, мөн тэдний оронд сэтгэл зүрхнийхээ бардамналд хөөрсөн тийм шинүүдийг адислан томилсон буюу.
- 6 Тийм ээ, мөн тэд хаан Ноа өөрийн хүмүүст тохоосон татваруудаар өөрсдийн залхуу, мөн өөрсдийн хиймлийг шүтэх явдалд, мөн өөрсдийн садар самуун явдлуудад тийн тэтгэгдсэн буюу; тийн нь алдсыг тэтгэхийн тулд уг хүмүүс үлэмж хөдөлмөрлөсөн ажээ.
- 7 Тийм ээ, мөн тэд хаан болон санваартнуудын хоосон мөн зусар үгсээр мэхлэгдсэн учир, түүнчлэн тэд хиймлийг шүтэгчид болов; учир нь тэдэнд зусардсан зүйлийг тэд ярьдаг байв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноа олон тансаг мөн цэлгэр барилгуудыг барьжээ; мөн тэрээр тэдгэрийг төрөл бүрийн үнэт зүйлүүдээр, модоор, мөн алт, мөн мөнгө, мөн төмөр, мөн гууль, мөн зиф, мөн зэсээр хийсэн уран эдлэлээр чимэглүүлсэн ажээ;

## Mosiah 11

And now it came to pass that Zeniff conferred the kingdom upon Noah, one of his sons; therefore Noah began to reign in his stead; and he did not walk in the ways of his father.

For behold, he did not keep the commandments of God, but he did walk after the desires of his own heart. And he had many wives and concubines. And he did cause his people to commit sin, and do that which was abominable in the sight of the Lord. Yea, and they did commit whoredoms and all manner of wickedness.

And he laid a tax of one fifth part of all they possessed, a fifth part of their gold and of their silver, and a fifth part of their ziff, and of their copper, and of their brass and their iron; and a fifth part of their fatlings; and also a fifth part of all their grain.

And all this did he take to support himself, and his wives and his concubines; and also his priests, and their wives and their concubines; thus he had changed the affairs of the kingdom.

For he put down all the priests that had been consecrated by his father, and consecrated new ones in their stead, such as were lifted up in the pride of their hearts.

Yea, and thus they were supported in their laziness, and in their idolatry, and in their whoredoms, by the taxes which king Noah had put upon his people; thus did the people labor exceedingly to support iniquity.

Yea, and they also became idolatrous, because they were deceived by the vain and flattering words of the king and priests; for they did speak flattering things unto them.

And it came to pass that king Noah built many elegant and spacious buildings; and he ornamented them with fine work of wood, and of all manner of precious things, of gold, and of silver, and of iron, and of brass, and of ziff, and of copper;

- 9 Мөн түүнчлэн тэрээр цэлгэр ордон, мөн түүний голд нь хаан сэнтийг өөртөө барьж тэдгээр нь бүгд сайн модоор хийгдэж мөн алт болон мөнгө мөн үнэт зүйлүүдээр чимэглэгдсэн байв.
- 10 Мөн түүнчлэн тэрээр ажилчдаараа сайн чанарын мод, мөн зэс, мөн гуулиар ариун сүмийн ханан дотор бүх төрлийн уран эдлэлийг хийх болгосон бөлгөө.
- 11 Мөн дээд санваартнуудын суухад зориулагдсан, бусад бүх суудлуудаас дээр байсан тэр суудлуудыг, тэр шижир алтаар чимэглэсэн аж; мөн тэр тэдний өмнө хашлага бариулав, хуурамч болоод хоосон үгсийг түүний хүмүүст ярьснаар тэд биеэ болон гараа амрааж болох ажгуу.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэрээр ариун сүмийн дэргэд цамхаг барив; тийм ээ, маш өндөр цамхаг, бүр тэрээр түүний дээр зогсоод Шилом нутгийг, мөн түүнчлэн леменчүүдээр эзэмшигдсэн, Шимлон нутгийг бүхэлд нь харж чадахаар өндөр буюу; мөн тэрээр бүр эргэн тойрныхоо бүх нутгийг харж чаддаг байв.
- 13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Шиломын нутагт олон барилга бариулав; мөн тэд нутгаас зугтан гарсан тэр цагт Нифайн хүүхдүүдэд хоргодох газар болсон Шилом нутгийн умардад толгой дээр агуу цамхаг бариулсан аж; мөн өөрийн хүмүүсээс татварлаж олсон тэрхүү баялгаараа тэрээр тийн хийсэн болой.
- 14 Мөнхүү улиран тохиох дор тэрээр зүрх сэтгэлээ баялгуудынхаа дээр тавьж, мөн тэр цагаа эхнэрүүд мөн татвар эмсийнхээ хамт шуугиант амьдралд өнгөрөөдөг байлаа; мөн түүний санваартнууд түүнчлэн цагаа садар эмстэй өнгөрөөдөг байв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор уг нутгийн эргэн тойронд тэрээр усан үзэм тариалжээ; мөн тэрээр усан үзэм дарагч барьж, мөн элбэг их дарс хийв; мөн тиймийн тул тэрээр мөн түүнчлэн хүмүүс нь ч дарсанд халагсад болов.
- 16 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд түүний хүмүүс дээр, цөөн тоогоороо байхад нь ирж эхлэв, мөн тэднийг өөрсдийнх нь талбай дээр, мөн тэднийг сүргээ хариулж явахад нь хөнөөж эхлэв.

And he also built him a spacious palace, and a throne in the midst thereof, all of which was of fine wood and was ornamented with gold and silver and with precious things.

And he also caused that his workmen should work all manner of fine work within the walls of the temple, of fine wood, and of copper, and of brass.

And the seats which were set apart for the high priests, which were above all the other seats, he did ornament with pure gold; and he caused a breastwork to be built before them, that they might rest their bodies and their arms upon while they should speak lying and vain words to his people.

And it came to pass that he built a tower near the temple; yea, a very high tower, even so high that he could stand upon the top thereof and overlook the land of Shilom, and also the land of Shemlon, which was possessed by the Lamanites; and he could even look over all the land round about.

And it came to pass that he caused many buildings to be built in the land Shilom; and he caused a great tower to be built on the hill north of the land Shilom, which had been a resort for the children of Nephi at the time they fled out of the land; and thus he did do with the riches which he obtained by the taxation of his people.

And it came to pass that he placed his heart upon his riches, and he spent his time in riotous living with his wives and his concubines; and so did also his priests spend their time with harlots.

And it came to pass that he planted vineyards round about in the land; and he built wine-presses, and made wine in abundance; and therefore he became a wine-bibber, and also his people.

And it came to pass that the Lamanites began to come in upon his people, upon small numbers, and to slay them in their fields, and while they were tending their flocks.

- 17 Мөн хаан Ноа тэднээс хамгаалуулахаар нутгийн-  
хаа эргэн тойронд харуулууд илгээв; гэвч тэр хан-  
галтгай тоогоор илгээсэнгүй, мөн леменчүүд тэдний  
дээр ирж мөн тэднийг хөнөөгөөд, мөн тэдний мал  
сүргээс олныг нь уг нутгаас тууж гаргав; тийн лемен-  
чүүд тэднийг устгаж мөн тэдний дээрх үзэн ядалтаа  
бодитой болгож эхлэв.
- 18 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноа их цэргээ  
тэдний эсрэг илгээж, мөн тэд гэдрэг туугдсан аж, өө-  
рөөр хэлбэл тэд тэднийг хэсэг зуур гэдрэг ухруулав;  
тиймийн тул, тэд олзондоо баясаад эргэж ирцгээв.
- 19 Мөн эдүгээ, энэ их ялалтын учир тэд зүрх сэтгэ-  
лийн бардамналд хөөрцгөөсөн байв; тэд хүчиндээ  
эрдэн сагсуурцгааж, тэдний тавь нь мянга мянган ле-  
менчүүдийн эсрэг зогсож чадна хэмээн өгүүлцгээв;  
мөн тэд тийн сагсуурцгааж, мөн цусанд, мөн ах дүү-  
сийнхээ цусыг урсгасандаа баясацгаав, мөн энэ нь  
тэдний хаан мөн санваартнуудын ёс бусын учир бу-  
юу.
- 20 Мөнхүү улиран тохиох дор Абинадай гэж нэрлэг-  
дэх нэгэн эр тэдний дунд байв; мөн тэрээр тэдний  
дундуур урагшлан явж, мөн бошиглож эхлэн, хэлсэн  
нь: Болгоогтун, Их Эзэн тийн хэлнэм, мөн ийн тэ-  
рээр надад зарлиглан, хэлрүүн, Урагш яв, мөн энэ хү-  
мүүст хэл, ийн Их Эзэн хэлнэм— Ай энэ хүмүүст ха-  
лаг, учир нь би тэдний жигшүүрт явдлууд, мөн тэд-  
ний ёс бус, мөн тэдний садар самуун явдлыг харсаар  
байна; мөн тэд наманчлахгүй аваас би хилэнгээрээ  
тэдэн дээр айлчлах болно.
- 21 Мөн тэд наманчилж мөн Их Эзэн Бурхандаа хан-  
дахгүй аваас, болгоогтун, би тэднийг дайсных нь  
гарт оруулах болно; тийм ээ, мөн тэд боолчлолд  
оруулагдах болно; мөн тэд дайснуудынхаа гараар зо-  
воогдох болно.
- 22 Мөнхүү улиран тохиох дор би бол Их Эзэн тэд-  
ний Бурхан, мөн би өөрийн хүмүүсийн алдсуудад  
айлчлах хартай Бурхан гэдгийг тэд мэдэх болно хэ-  
мээв.
- 23 Мөнхүү улиран тохиох дор энэ хүмүүс наман-  
чилж мөн Их Эзэн Бурхандаа хандахгүй аваас, тэд  
боолчлолд оруулагдах болно; мөн энэ нь Их Эзэн  
Бүхнийг Чадагч Бурхан байхаас бусдаар бол хэн ч  
тэднийг чөлөөлөхгүй.

And king Noah sent guards round about the land to  
keep them off; but he did not send a sufficient number,  
and the Lamanites came upon them and killed them,  
and drove many of their flocks out of the land; thus the  
Lamanites began to destroy them, and to exercise their  
hatred upon them.

And it came to pass that king Noah sent his armies  
against them, and they were driven back, or they drove  
them back for a time; therefore, they returned rejoicing  
in their spoil.

And now, because of this great victory they were  
lifted up in the pride of their hearts; they did boast in  
their own strength, saying that their fifty could stand  
against thousands of the Lamanites; and thus they did  
boast, and did delight in blood, and the shedding of the  
blood of their brethren, and this because of the wicked-  
ness of their king and priests.

And it came to pass that there was a man among  
them whose name was Abinadi; and he went forth  
among them, and began to prophesy, saying: Behold,  
thus saith the Lord, and thus hath he commanded me,  
saying, Go forth, and say unto this people, thus saith  
the Lord—Wo be unto this people, for I have seen their  
abominations, and their wickedness, and their whore-  
doms; and except they repent I will visit them in mine  
anger.

And except they repent and turn to the Lord their  
God, behold, I will deliver them into the hands of their  
enemies; yea, and they shall be brought into bondage;  
and they shall be afflicted by the hand of their enemies.

And it shall come to pass that they shall know that I  
am the Lord their God, and am a jealous God, visiting  
the iniquities of my people.

And it shall come to pass that except this people re-  
pent and turn unto the Lord their God, they shall be  
brought into bondage; and none shall deliver them, ex-  
cept it be the Lord the Almighty God.

- 24 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор тэд надад залбиран гуйх үед тэдний гуйлтуудыг сонсохдоо би удаан байх болно; тийм ээ, мөн тэд дайснуудаараа нам цохигдохыг би тэдэнд зөвшөөрөх болно.
- 25 Мөн тэд үнс түрхэн мөн таар нөмөрч наманчлан, мөн Их Эзэн Бурхандаа хүчтэйгээр залбиран гуйхгүй аваас, би тэдний залбирлуудыг сонсохгүй, бас би тэднийг зовлонгоос нь ч чөлөөлөхгүй байх болно; мөн Их Эзэн тийн хэлнэм, мөн тэрээр надад тийн зарлигласан болой.
- 26 Эдүгээ улиран тохиох дор Абинадай эдгээр үгсийг тэдэнд ярихад тэд түүнд хилэгнэж, мөн түүний амийг авахаар эрэлхийлэв; гэвч Их Эзэн тэдний гараас түүнийг чөлөөлөв.
- 27 Эдүгээ хаан Ноа Абинадайн хүмүүст ярьсан тэр үгсийг дуулаад, тэрээр түүнчлэн хилэгнэв; мөн тэрээр хэлэв: Би болон миний хүмүүс түүгээр шүүгдэх, Абинадай гэж хэн бэ, эсвээс миний хүмүүсийн дээр тийм агуу зовлон авчрах Их Эзэн гэж хэн бэ
- 28 Би түүнийг алж болохын тулд Абинадаг энд авчрахыг би та нарт тушааж байна, учир нь тэр эдгээр зүйлийг минь хүмүүсийг өөр хооронд нь уурлуулахаар өдөөн хатгаж, мөн миний хүмүүсийн дунд зөрчилдөөн үүсгэж болно хэмээн хэлжээ; тиймийн тул би түүнийг хөнөөх болно.
- 29 Эдүгээ хүмүүсийн нүд харалган болсон байв; тиймийн тул тэд Абинадайн үгсийн эсрэг зүрх сэтгэлээ хатууруулж, мөн тэд тэр цагаас хойшид түүнийг барихаар эрэлхийлсэн буюу. Мөн Их Эзэний үгсийн эсрэг хаан Ноа зүрх сэтгэлээ хатууруулж, мөн тэрээр хилэнцэт үйлүүдээ наманчилсан нь үгүй.

Yea, and it shall come to pass that when they shall cry unto me I will be slow to hear their cries; yea, and I will suffer them that they be smitten by their enemies.

And except they repent in sackcloth and ashes, and cry mightily to the Lord their God, I will not hear their prayers, neither will I deliver them out of their afflictions; and thus saith the Lord, and thus hath he commanded me.

Now it came to pass that when Abinadi had spoken these words unto them they were wroth with him, and sought to take away his life; but the Lord delivered him out of their hands.

Now when king Noah had heard of the words which Abinadi had spoken unto the people, he was also wroth; and he said: Who is Abinadi, that I and my people should be judged of him, or who is the Lord, that shall bring upon my people such great affliction?

I command you to bring Abinadi hither, that I may slay him, for he has said these things that he might stir up my people to anger one with another, and to raise contentions among my people; therefore I will slay him.

Now the eyes of the people were blinded; therefore they hardened their hearts against the words of Abinadi, and they sought from that time forward to take him. And king Noah hardened his heart against the word of the Lord, and he did not repent of his evil doings.

## Мозая 12

- 1 Мөнхүү улиран тохиох дор хоёр жилийн дараа Абинадай, тэд түүнийг эс мэдэхийн тул тэдний дунд зүсээ хувирган ирж, мөн тэдний дунд бошиглож эхлэн, өгүүлсэн нь: Тийн Их Эзэн надад зарлигласан буюу, хэлрүүн—Абинадай, явагтун мөн миний энэ хүмүүст бошигло, учир нь тэд зүрх сэтгэлээ миний үгсийн эсрэг хатууруулсан; тэд хилэнцэт үйлүүдээ наманчилсан нь үгүй; тиймийн тул, тэдэнд би уурандаа айлчилна, тийм ээ, тэдний алдсууд хийгээд жигшүүрт хэргүүдэд би догшин уурандаа айлчлах болно.
- 2 Тийм ээ, энэ үеийнхэнд халаг! Мөн Их Эзэн надад хэлэв: Гараа урагш сунгагтун мөн бошигло, хэлсэн нь: улиран тохиох дор энэ үеийнхэн өөрсдийн алдсуудын учир боолчлолд авчрагдах болно, мөн хацар дээрээ цохиулах болно; тийм ээ, хүмүүнээр хөөгдөх болно, мөн алагдах болно; мөн тэдний махбодийг нь дээр агаарт буй тас, мөн ноход, тийм ээ, мөн зэрлэг араатнууд цөлмөх болно хэмээн Их Эзэн тийн хэллээ.
- 3 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноагийн амьдрал бүр халуун зууханд орсон хувцас лугаа адил үнэлэгдэх болно; учир нь би бол Их Эзэн гэдгийг тэрээр мэдэх болно.
- 4 Мөнхүү улиран тохиох дор би өөрийн энэ хүмүүсийг зовлонт зүдрэлүүдээр цохих болно, тийм ээ, өлсгөлөн мөн тахлаар; мөн би тэднийг бүхэл өдрийн турш уйлан хайлах болгоно.
- 5 Тийм ээ, мөн үүрэг ачаанууд нуруунд нь хүлэгдэхээр болгоно би; мөн тэд хэлгүй илжиг мэт туугдах болно.
- 6 Мөнхүү улиран тохиох дор би тэдний дунд мөндөр илгээнэ, мөн энэ нь тэднийг цохих болно; мөн тэд түүнчлэн дорнын салхинд цохигдох болно; мөн шавьжнууд тэдний нутгийг түүнчлэн зовоож, мөн тэдний үр тариаг цөлмөх болно.
- 7 Мөн тэд аймшигт тахлаар цохигдох болно—мөн энэ бүгдийг тэдний алдсууд мөн жигшүүрт хэргүүдийн учир хийх болно би.

## Mosiah 12

And it came to pass that after the space of two years that Abinadi came among them in disguise, that they knew him not, and began to prophesy among them, saying: Thus has the Lord commanded me, saying—Abinadi, go and prophesy unto this my people, for they have hardened their hearts against my words; they have repented not of their evil doings; therefore, I will visit them in my anger, yea, in my fierce anger will I visit them in their iniquities and abominations.

Yea, wo be unto this generation! And the Lord said unto me: Stretch forth thy hand and prophesy, saying: Thus saith the Lord, it shall come to pass that this generation, because of their iniquities, shall be brought into bondage, and shall be smitten on the cheek; yea, and shall be driven by men, and shall be slain; and the vultures of the air, and the dogs, yea, and the wild beasts, shall devour their flesh.

And it shall come to pass that the life of king Noah shall be valued even as a garment in a hot furnace; for he shall know that I am the Lord.

And it shall come to pass that I will smite this my people with sore afflictions, yea, with famine and with pestilence; and I will cause that they shall howl all the day long.

Yea, and I will cause that they shall have burdens lashed upon their backs; and they shall be driven before like a dumb ass.

And it shall come to pass that I will send forth hail among them, and it shall smite them; and they shall also be smitten with the east wind; and insects shall pester their land also, and devour their grain.

And they shall be smitten with a great pestilence— and all this will I do because of their iniquities and abominations.



- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд наманчлахгүй аваас би тэднийг газрын гадаргуу дээрээс бүрмөсөн устгах болно би; гэсэн хэдий ч тэд цэдгийг ардаа орхих болно, мөн би тэднийг уг нутгийг эзэмших тэр бусад үндэстнүүдийн тул хадгалан үлдээх болно; тийм ээ, бүр би үүнийг энэ хүмүүсийн жигшүүрт хэргүүдийг бусад үндэстнүүдэд мэдүүлж болохын тулд хийх болно. Мөн энэ хүмүүсийн эсрэг олон зүйлийг Абинадай бошиглов.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнд уурлав; мөн тэд түүнийг барьж мөн хүлээд хааны өмнө аваачаад, мөн хаанд: Болгоогтун, бид таны өмнө таны хүмүүсийн талаар хилэнцтийг бошиглосон мөн Бурхан тэднийг устгах болно хэмээсэн тэр хүнийг авчирлаа гэв.
- 10 Мөн тэрээр түүнчлэн таны амьдралын талаар хилэнцтийг бошиглож, мөн таны амьдрал халуун зууханд орсон хувцас лугаа адил байх болно хэмээн хэлсэн бөлгөө.
- 11 Мөн түүнчлэн тэрээр таныг дээгүүр нь мал амьтад гүйлдэж, мөн хөл дор дэвслэгдсэн сүрэл шиг, бүр талбайд хатсан сүрэл лугаа адил байх болно хэмээв.
- 12 Мөн түүнчлэн, тэрээр таныг боловсорч гүйцмэгц, хэрэв салхи үлээвэл, энэ нь газрын гадаргуугаар тархах, цэцэглэж буй багваахай цэцэг лугаа адил байх болно гэж хэллээ. Мөн тэрээр Их Эзэн үүнийг ярьсан мэт дүр эсгэх ажгуу. Мөн та наманчлахгүй аваас энэ бүгд таны дээр ирэх бөгөөд энэ нь таны алдсудын учир болой хэмээн тэрээр хэлэв.
- 13 Мөн эдүгээ, Ай хаантан, энэ хүнээр шүүлгэх эсвээс Бурханаар буруушаагдахаар ямар агуу хилэнц гэгчийг та хийсэн билээ, эсвээс таны хүмүүс ямар их нүглүүдийг үйлдсэн билээ
- 14 Мөн эдүгээ, Ай хаантан, болгоогтун, бид гэмгүй, та ч мөн адил, Ай хаантан, нүгэл үйлдээгүй; тиймийн тул, энэ хүн таны талаар худлаа ярьсан, мөн тэрээр хоосон бошиглосон бөлгөө.
- 15 Мөн болгоогтун, бид хүчирхэг, бид боолчлолд орохгүй, өөрөөр хэлбэл дайснуудаараа боолчлолд аваачигдахгүй; тийм ээ, мөн та энэ нутагт дэгжсэн, мөн та түүнчлэн дэгжих болно.

And it shall come to pass that except they repent I will utterly destroy them from off the face of the earth; yet they shall leave a record behind them, and I will preserve them for other nations which shall possess the land; yea, even this will I do that I may discover the abominations of this people to other nations. And many things did Abinadi prophesy against this people.

And it came to pass that they were angry with him; and they took him and carried him bound before the king, and said unto the king: Behold, we have brought a man before thee who has prophesied evil concerning thy people, and saith that God will destroy them.

And he also prophesieth evil concerning thy life, and saith that thy life shall be as a garment in a furnace of fire.

And again, he saith that thou shalt be as a stalk, even as a dry stalk of the field, which is run over by the beasts and trodden under foot.

And again, he saith thou shalt be as the blossoms of a thistle, which, when it is fully ripe, if the wind bloweth, it is driven forth upon the face of the land. And he pretendeth the Lord hath spoken it. And he saith all this shall come upon thee except thou repent, and this because of thine iniquities.

And now, O king, what great evil hast thou done, or what great sins have thy people committed, that we should be condemned of God or judged of this man?

And now, O king, behold, we are guiltless, and thou, O king, hast not sinned; therefore, this man has lied concerning you, and he has prophesied in vain.

And behold, we are strong, we shall not come into bondage, or be taken captive by our enemies; yea, and thou hast prospered in the land, and thou shalt also prosper.

16 Болгоогтун, тэр хүн энд байна, бид түүнийг таны гарт өглөө; та өөрийн сайн гэж үзсэнийг түүнд үйлдэж болох буюу.

17 Мөнхүү улиран тохиох дор хаан Ноа Абинадайг шоронд хорихоор болгов; мөн тэрээр түүнийг ях ёстой талаар тэдэнтэй зөвлөгөөн хийж болохын тулд санваартнуудыг цугларахыг тушаав.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд хаанд: Бид түүнийг байцааж болохын тулд түүнийг нааш авчир гэж хэлэв; мөн хаан түүнийг тэдний өмнө авчрагдах ёстой хэмээн зарлиг болов.

19 Мөн тэд түүнийг байцааж эхлэв, тэд түүнийг үүний төлөө буруутгаж болохын тулд түүний үгсийг авцалдахгүй болгоно хэмээв; гэвч тэрээр тэдэнд зоригтойгоор хариулж, мөн тэдний бүх асуултуудыг давж гаран, тийм ээ, тэдний гайхлыг төрүүлж; учир нь тэрээр тэдний бүх асуултуудыг давж гаран, мөн өөрсдийнх нь бүх үгсэд тэднийг ичгүүрлэсэн аж.

20 Мөнхүү улиран тохиох дор тэдний нэг нь түүнд хэлэв: Бичигдсэн буй, мөн бидний эцэг өвгөдөөр сургагдсан энэхүү үгс ямар утгатай билээ, өгүүлсэн нь:

21 Баярт мэдээнүүдийг авчирдаг; амар амгаланг тунхаглана; сайны тухай баярт мэдээнүүдийг авчирдаг; авралыг тунхагладаг; Таны Бурхан хаанчлан буй хэмээн Сионд хэлэх түүний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ;

22 Таны харуулууд дуу хоолойгоо өргөх болно; тэд дуу хоолойгоор хамтдаа дуулна; учир нь Их Эзэн Сионыг дахин авчрахыг тэд нүдээр үзэх болно;

23 Баясацгаа; Иерусалимын зэлүүд газрууд та нар хамтдаа дуулцгаа; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулж, тэрээр Иерусалимыг гэтэлгэсэн болой;

24 Их Эзэн өөрийн ариун мутрыг бүх үндэстнүүдийн нүдэнд харуулсан, мөн газар дэлхийн бүх хязгаарууд Бурханы минь авралыг үзэх үү

25 Мөн эдүгээ Абинадай тэдэнд хэлэв: Та нар санваартнууд, мөн энэ хүмүүст сургадаг, мөн бошиглолын суу билгийг ойлгодог дүр эсгэдэг, мөн тэгсэн хэдий ч эдгээр зүйлүүд ямар утгатайг надаас мэдэхийг хүснэ гэж үү

Behold, here is the man, we deliver him into thy hands; thou mayest do with him as seemeth thee good.

And it came to pass that king Noah caused that Abinadi should be cast into prison; and he commanded that the priests should gather themselves together that he might hold a council with them what he should do with him.

And it came to pass that they said unto the king: Bring him hither that we may question him; and the king commanded that he should be brought before them.

And they began to question him, that they might cross him, that thereby they might have wherewith to accuse him; but he answered them boldly, and withstood all their questions, yea, to their astonishment; for he did withstand them in all their questions, and did confound them in all their words.

And it came to pass that one of them said unto him: What meaneth the words which are written, and which have been taught by our fathers, saying:

How beautiful upon the mountains are the feet of him that bringeth good tidings; that publisheth peace; that bringeth good tidings of good; that publisheth salvation; that saith unto Zion, Thy God reigneth;

Thy watchmen shall lift up the voice; with the voice together shall they sing; for they shall see eye to eye when the Lord shall bring again Zion;

Break forth into joy; sing together ye waste places of Jerusalem; for the Lord hath comforted his people, he hath redeemed Jerusalem;

The Lord hath made bare his holy arm in the eyes of all the nations, and all the ends of the earth shall see the salvation of our God?

And now Abinadi said unto them: Are you priests, and pretend to teach this people, and to understand the spirit of prophesying, and yet desire to know of me what these things mean?

26 Би та нарт хэлнэ, Их Эзэний замуудыг гажуудуулсны төлөө та нарт халаг ирэг! Учир нь, хэрэв та нар эдгээр зүйлүүдийг ойлгодог бол та нар эдгээрийг сургасан нь үгүй; тиймийн тул, та нар Их Эзэний замуудыг гажуудуулжээ.

27 Та нар ойлгохын тул зүрх сэтгэлээ зориулсангүй; тиймийн тул, та нар мэргэн байсангүй. Тиймийн тул, та нар энэ хүмүүст юу заах билээ

28 Мөн тэд хэлэв: Бид Мосегийн хуулийг заадаг.

29 Мөн түүнчлэн тэрээр тэдэнд хэлэв: Хэрэв та нар Мосегийн хуулийг заадаг аваас яагаад та нар үүнийг сахьдаггүй билээ? Яагаад та нар зүрх сэтгэлээ баялгуудын дээр тавих болов? Их Эзэн намайг энэ хүмүүсийн эсрэг, тийм ээ, бүр агуу хилэнцийг энэ хүмүүсийн эсрэг бошиглуулахаар илгээхэд хүргэн, та нар яагаад садар самууныг үйлдэж, мөн өөрсдийн хүчийг садар эмстэй барж, тийм ээ, мөн энэ хүмүүсийг нүгэл үйлдэхэд хүргэв

30 Үнэнийг ярьж буйг минь та нар эс мэднэ гэж үү? Тийм ээ, би үнэнийг ярьж буйг та нар мэднэ; мөн та нар Бурханы өмнө айн чичирвэл зохилтой.

31 Мөнхүү улиран тохиох дор та нар алдсынхаа учир цохигдох болно, учир нь та нар Мосегийн хуулийг заадаг хэмээн хэлэв. Мөн та нар Мосегийн хуулийн талаар юу мэдэх билээ? Аврал Мосегийн хуулиар ирэх үү? Та нар юу хэлэх вэ

32 Мөн тэд хариулж, аврал Мосегийн хуулиар ирдэг гэв.

33 Харин эдүгээ Абинадай тэдэнд хэлсэн нь: Хэрэв та нар Бурханы зарлигуудыг дагавал та нар аврагдах болно гэдгийг би мэднэ; тийм ээ, хэрэв та нар Их Эзэн Синайн ууланд Мосед дамжуулсан энэхүү зарлигуудыг дагавал, өгүүлсэн нь:

34 Би бол Их Эзэн чиний Бурхан, чамайг Египетийн нутгаас, боолчлолын үүрнээс авчирсан тэр буюу.

35 Чи миний өмнө өөр Бурхан байлгах ёсгүй.

36 Та нар өөрсдөдөө нэгээхэн ч зормол дүрсийг, эсвээс дээр тэнгэрт буй эсвээс доор газарт буй ямар ч зүйлийг дуурайлган хийх ёсгүй.

I say unto you, wo be unto you for perverting the ways of the Lord! For if ye understand these things ye have not taught them; therefore, ye have perverted the ways of the Lord.

Ye have not applied your hearts to understanding; therefore, ye have not been wise. Therefore, what teach ye this people?

And they said: We teach the law of Moses.

And again he said unto them: If ye teach the law of Moses why do ye not keep it? Why do ye set your hearts upon riches? Why do ye commit whoredoms and spend your strength with harlots, yea, and cause this people to commit sin, that the Lord has cause to send me to prophesy against this people, yea, even a great evil against this people?

Know ye not that I speak the truth? Yea, ye know that I speak the truth; and you ought to tremble before God.

And it shall come to pass that ye shall be smitten for your iniquities, for ye have said that ye teach the law of Moses. And what know ye concerning the law of Moses? Doth salvation come by the law of Moses? What say ye?

And they answered and said that salvation did come by the law of Moses.

But now Abinadi said unto them: I know if ye keep the commandments of God ye shall be saved; yea, if ye keep the commandments which the Lord delivered unto Moses in the mount of Sinai, saying:

I am the Lord thy God, who hath brought thee out of the land of Egypt, out of the house of bondage.

Thou shalt have no other God before me.

Thou shalt not make unto thee any graven image, or any likeness of any thing in heaven above, or things which are in the earth beneath.

37 Эдүгээ Абинадай тэдэнд хэлэв, Та нар энэ бүгдийг сахьсан уу? Би та нарт хэлнэм, Үгүй, та нар тэгсэнгүй. Мөн та нар энэ хүмүүст тэд эдгээр зүйлүүдийг хийх ёстойг сургасан уу? Би та нарт хэлнэ, Үгүй, та нар тэгээгүй.

Now Abinadi said unto them, Have ye done all this? I say unto you, Nay, ye have not. And have ye taught this people that they should do all these things? I say unto you, Nay, ye have not.

## Мозая 13

- 1 Мөн эдүгээ хаан эдгээр үгсийг сонсоод, тэрээр санваартнууддаа хэлэв: Энэ хүнийг зайлуул, мөн түүнийг хөнөө; өөрөөр хэлбэл бид түүгээр юу хийхэв, учир нь тэр галзуу юм.
- 2 Мөн тэд урагш босож мөн түүний дээр гараа хүрэхийг оролдов; гэвч тэрээр тэднийг эсэргүүцэж, мөн тэдэнд хэлэв:
- 3 Надад бүү хүр, учир нь хэрэв та нар надад гар хүрвэл Бурхан та нарыг цохих болно, учир нь дамжуулахын тулд Их Эзэн намайг илгээсэн тэрхүү мэдээг би дамжуулаагүй байна; бас надаар та нарын хэлүүлэхийг хүссэнийг ч би хэлээгүй байна; тиймийн тул, Бурхан намайг энэ цагт устгагдахыг зөвшөөрөхгүй.
- 4 Харин Бурхан надад зарлигласан болгоныг би гүйцэлдүүлэх ёстой; мөн та нарт би үнэнийг хэлсэн учир та нар надад уурлах бөлгөө. Мөн түүнчлэн, би Бурханы үгийг ярьсан учир та нар намайг галзуу хэмээн шийдсэн болой.
- 5 Эдүгээ улиран тохиох дор Абинадай эдгээр үгсийг ярьсны дараа хаан Ноагийн хүмүүс түүнд гараа хүргэж зүрхэлсэнгүй, учир нь Их Эзэний Сүнс түүний дээр байв; мөн түүний царай үлэмж гэрлээр, бүр Мосе Синай ууланд Их Эзэнтэй ярьж байсан үеийнхтэй адилаар туяаран байв.
- 6 Мөн тэрээр Бурханаас авсан хүч мөн эрх мэдэлтэйгээр ярьж байв; мөн тэрээр өөрийн үгсийг үргэлжлүүлж, хэлсэн нь:
- 7 Намайг алах хүч та нарт үгүй гэдгийг та нар харж байна, тиймийн тул би өөрийн хэлэхийг дуусгая. Тийм ээ, мөн та нарын алдсуудын талаар би та нарт үнэнийг хэлсэн учраас энэ нь та нарын зүрхэнд чинь хүртэл зүсэж буйг би харж байна.
- 8 Тийм ээ, мөн миний үгс та нарыг гайхашрал мөн хачирхлаар, мөн уур хилэнгээр дүүргэх бөлгөө.
- 9 Гэвч би хэлэхээ дуусгая; мөн тэгээд, хэрэв би аврагдах аваас хаашаа би явах нь хамаагүй бөлгөө.
- 10 Харин би үүнийг та нарт хэлнэ, үүний дараа та нар намайг яах нь, тэр нь ирэх тэрхүү зүйлүүдийн хэв шинж мөн сүүдэр байх болно.

## Mosiah 13

And now when the king had heard these words, he said unto his priests: Away with this fellow, and slay him; for what have we to do with him, for he is mad.

And they stood forth and attempted to lay their hands on him; but he withstood them, and said unto them:

Touch me not, for God shall smite you if ye lay your hands upon me, for I have not delivered the message which the Lord sent me to deliver; neither have I told you that which ye requested that I should tell; therefore, God will not suffer that I shall be destroyed at this time.

But I must fulfil the commandments wherewith God has commanded me; and because I have told you the truth ye are angry with me. And again, because I have spoken the word of God ye have judged me that I am mad.

Now it came to pass after Abinadi had spoken these words that the people of king Noah durst not lay their hands on him, for the Spirit of the Lord was upon him; and his face shone with exceeding luster, even as Moses' did while in the mount of Sinai, while speaking with the Lord.

And he spake with power and authority from God; and he continued his words, saying:

Ye see that ye have not power to slay me, therefore I finish my message. Yea, and I perceive that it cuts you to your hearts because I tell you the truth concerning your iniquities.

Yea, and my words fill you with wonder and amazement, and with anger.

But I finish my message; and then it matters not whither I go, if it so be that I am saved.

But this much I tell you, what you do with me, after this, shall be as a type and a shadow of things which are to come.

11 Мөн эдүгээ би та нарт Бурханы зарлигуудын үлдсэнийг нь уншъя, учир нь тэдгээр нь та нарын зүрх сэтгэлд бичигдсэн нь үгүй гэдгийг би харна; та нар амьдралынхаа ихэнх хэсэгт алдаст суралцаж мөн сургасныг би харж байна.

12 Мөн эдүгээ би та нарт: Та нар өөртөө нэгээхэн ч зормол дүрсийг, эсвээс дээд тэнгэрт буй эсвээс доор газарт буй, эсвээс газар доор усанд буй ямар ч зүйлийг дуурайлган хийх ёсгүй хэмээн хэлснийг та нар санаж байгаа.

13 Мөн түүнчлэн: Чи өөрийгөө тэдэнд бөхөлзүүлж, мөн тэдэнд үйлчлэх ч ёсгүй; учир нь би Их Эзэн чиний Бурхан бол хартай Бурхан, эцгүүдийнх нь алдсуудын учир хүүхдүүдийнх нь дээр, намайг үзэн ядах тэдний гурав дахь мөн дөрөв дэх үед нь хүртэл зочилно;

14 Мөн намайг хайрлах мөн миний зарлигуудыг дагах тэдний мянга мянгад нь нигүүлслийг үзүүлэх болно.

15 Чи Их Эзэн мөн Бурханыхаа нэрийг хоосноор бүү дурд; учир нь Их Эзэн түүний нэрийг хоосноор дурдах түүнийг гэмгүй хэмээн эс тооцох болно.

16 Хүндэтгэлийн өдрийг, үүнийг ариунаар хадгалыхын тулд сана.

17 Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, мөн бүх ажлаа хийх болно.

18 Харин долоо дахь өдөр, Их Эзэн Бурханыхаа хүндэтгэлийн өдөр, чи ямар ч ажил хийх ёсгүй, чи, мөн чиний хүү ч, чиний охин ч, чиний зарц ч, чиний шивэгчин ч, чиний мал сүрэг ч, мөн чиний хаалгаар орж ирсэн үл таних хүн ч нэгэн адил;

19 Учир нь Их Эзэн зургаан өдөрт тэнгэр ба газрыг, мөн далайг, мөн тэдгээрийн дээрх бүхнийг хийсэн юм; тиймийн тул Их Эзэн хүндэтгэлийн өдрийг адисалсан, мөн үүнийг ариулсан болой.

20 Их Эзэн Бурхан тань чамд өгсөн тэр нутаг дээр чиний өдрүүд урт байж болохын тулд Эцэг, эхээ хүндэл.

21 Чи хүн бүү ал.

22 Чи садар самууныг үйлдэх ёсгүй. Чи хулгайлах ёсгүй.

23 Чи хөршийнхөө эсрэг хуурамчаар гэрчлэх ёсгүй.

And now I read unto you the remainder of the commandments of God, for I perceive that they are not written in your hearts; I perceive that ye have studied and taught iniquity the most part of your lives.

And now, ye remember that I said unto you: Thou shalt not make unto thee any graven image, or any likeness of things which are in heaven above, or which are in the earth beneath, or which are in the water under the earth.

And again: Thou shalt not bow down thyself unto them, nor serve them; for I the Lord thy God am a jealous God, visiting the iniquities of the fathers upon the children, unto the third and fourth generations of them that hate me;

And showing mercy unto thousands of them that love me and keep my commandments.

Thou shalt not take the name of the Lord thy God in vain; for the Lord will not hold him guiltless that taketh his name in vain.

Remember the sabbath day, to keep it holy.

Six days shalt thou labor, and do all thy work;

But the seventh day, the sabbath of the Lord thy God, thou shalt not do any work, thou, nor thy son, nor thy daughter, thy man-servant, nor thy maid-servant, nor thy cattle, nor thy stranger that is within thy gates;

For in six days the Lord made heaven and earth, and the sea, and all that in them is; wherefore the Lord blessed the sabbath day, and hallowed it.

Honor thy father and thy mother, that thy days may be long upon the land which the Lord thy God giveth thee.

Thou shalt not kill.

Thou shalt not commit adultery. Thou shalt not steal.

Thou shalt not bear false witness against thy neighbor.

24 Чи хөршийнхөө байшинд шунах ёсгүй, чи хөршийнхөө эхнэрт, бас түүний зарцад, түүний шивэгчинд ч, түүний шар, түүний илжиг, хөршийнх чинь болох юунд ч шунах ёсгүй.

25 Мөнхүү улиран тохиох дор Абинадай эдгээр үгээ төгсгөл болгосны дараа тэрээр тэдэнд хэлэв: Эдгээр зарлигуудыг дагахын тулд тэд эдгээр бүх зүйлийг хийхээр чармайх ёстойг та нар энэ хүмүүст заасан гэж үү

26 Би та нарт хэлнэ, Үгүй; учир нь хэрэв та нар тэгсэн бол, Их Эзэн намайг энд ирүүлж мөн энэ хүмүүсийн талаар хилэнцтийг бошиглуулахгүй байх байсан.

27 Мөн эдүгээ та нар Мосегийн хуулиар аврал ирнэ хэмээн хэллээ. Одоогоор Мосегийн хуулийг дагах ёстой нь зайлшгүйг би та нарт хэлье; гэвч би та нарт хэлнэ, Мосегийн хуулийг дагах нь цаашид зайлшгүй байхаа болих тэр цаг ирэх болно.

28 Мөн үүнээс гадна би та нарт хэлнэ, аврал зөвхөн хуулиар ирэх нь үгүй; мөн Бурхан өөрийн хүмүүсийн нүглүүд хийгээд алдсуудын учир өөрөө хийх тэрхүү цагаатгал үгүй аваас Мосегийн хууль байлаа ч, тэд гарах аргагүйгээр мөхөх ёстой болно.

29 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, Израилын хүүхдүүдэд хууль өгөгдөх нь зайлшгүй байв, тийм ээ, бүр маш хатуу хууль; учир нь тэд зөрүүд хүмүүс, алдсыг үйлдэхдээ хурдан, мөн Их Эзэн Бурханаа санахдаа хойрго байсан болой;

30 Тиймийн тул тэдэнд хууль өгөгдсөн байв, тийм ээ, гүйцэтгэлүүдийн хийгээд ёслолуудын хууль, Бурханыг мөн түүний өмнө хүлээсэн өөрсдийнх нь үүргийг тэдэнд сануулж байхын тулд, тэд өдрөөс өдөрт чандаар мөрдөх ёстой тэрхүү хууль болой.

31 Гэвч болгоогтун, би та нарт хэлнэ, эдгээр бүх зүйл ирэх зүйлүүдийн хэв шинж байв.

32 Мөн эдүгээ, тэд хуулийг ойлгосон уу? Би та нарт хэлнэ, Үгүй, тэд бүгд хуулийг ойлгосон нь үгүй; мөн энэ нь тэдний зүрх сэтгэлийн хатуугийн учир болой; учир нь тэд Бурханы гэтэлгэлийн гадуур аваас хэн боловч аврагдаж чадахгүйг ойлгосонгүй.

Thou shalt not covet thy neighbor's house, thou shalt not covet thy neighbor's wife, nor his manservant, nor his maid-servant, nor his ox, nor his ass, nor anything that is thy neighbor's.

And it came to pass that after Abinadi had made an end of these sayings that he said unto them: Have ye taught this people that they should observe to do all these things for to keep these commandments?

I say unto you, Nay; for if ye had, the Lord would not have caused me to come forth and to prophesy evil concerning this people.

And now ye have said that salvation cometh by the law of Moses. I say unto you that it is expedient that ye should keep the law of Moses as yet; but I say unto you, that the time shall come when it shall no more be expedient to keep the law of Moses.

And moreover, I say unto you, that salvation doth not come by the law alone; and were it not for the atonement, which God himself shall make for the sins and iniquities of his people, that they must unavoidably perish, notwithstanding the law of Moses.

And now I say unto you that it was expedient that there should be a law given to the children of Israel, yea, even a very strict law; for they were a stiffnecked people, quick to do iniquity, and slow to remember the Lord their God;

Therefore there was a law given them, yea, a law of performances and of ordinances, a law which they were to observe strictly from day to day, to keep them in remembrance of God and their duty towards him.

But behold, I say unto you, that all these things were types of things to come.

And now, did they understand the law? I say unto you, Nay, they did not all understand the law; and this because of the hardness of their hearts; for they understood not that there could not any man be saved except it were through the redemption of God.

33 Учир нь болгоогтун, Мессиагийн ирэлтийн талаар, мөн Бурхан өөрийн хүмүүсийг гэтэлгэх ёстойг Мосе тэдэнд бошиглоогүй гэж үү? Тийм ээ, мөн дэлхий эхэлснээс хойш бошиглож асан бүр бүх бошиглогчид—тэд эдгээр зүйлийн талаар их бага боловч ярьсан бус уу

34 Тэд Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирж, мөн хүний хэлбэрийг өөртөө авч, мөн газрын гадаргуу дээр их хүчтэйгээр урагшлан явахыг тэд хэлсэн бус уу

35 Тийм ээ, мөн түүнчлэн тэрээр үхэгсдийн амилуулалтыг улируулан тохиолгож, мөн тэр, өөрөө, хавчигдан мөн зовоогдох ёстойг тэд хэлсэн бус уу

For behold, did not Moses prophesy unto them concerning the coming of the Messiah, and that God should redeem his people? Yea, and even all the prophets who have prophesied ever since the world began—have they not spoken more or less concerning these things?

Have they not said that God himself should come down among the children of men, and take upon him the form of man, and go forth in mighty power upon the face of the earth?

Yea, and have they not said also that he should bring to pass the resurrection of the dead, and that he, himself, should be oppressed and afflicted?



## Мозая 14

- 1 Тийм ээ, бүр Исаиа хэлсэн бус уу: Хэн бидний цэдэгт итгэж, мөн хэнд Их Эзэний мугар илчлэгдсэн билээ
- 2 Учир нь тэрээр түүний өмнө зулзаган нахиа мэт мөн хуурай газраас гарах үндэс лугаа адил ургах болно; тэрээр онцгой хэлбэр мөн гоо сайхан ч үгүй байна; мөн бид түүнийг харахад бид түүнийг хүсмээр сайхан нь түүнд үгүй байх болно.
- 3 Тэрээр хүмүүнээр гадуурхагдаж мөн үл тоомсорлогдсон болно; харамсагч нэгэн мөн гашуудлыг танин мэдсэн бөлгөө; мөн бид түүнээс нүүрээ нуусан мэт байх болно; тэрээр гадуурхагдаж, мөн бид түүнийг хүндэтгэх нь үгүй.
- 4 Гарцаагүй тэр бидний гашуудлыг хүлээн авч, мөн бидний харамслыг үүрсэн; гэсэн хэдий ч бид түүнийг шаналсан, Бурханаар цохигдсон, мөн зовоогдсон хэмээн бодох болно.
- 5 Гэвч тэрээр бидний зөрчлүүдийн төлөө шархадна, тэрээр бидний алдсуудын төлөө зодуулан хөх няц болно; бидний амгалангийн төлөөс түүний дээр байх болно; мөн түүний шархны судлаар бид анагаагдах буюу.
- 6 Бид бүгд, хонь лугаа адил, төөрч одсон; бид нэг бүрээрээ өөрийн замыг хөөж одсон; мөн бид бүгд өөрсдийн алдсуудыг Их Эзэн түүний дээр үүрүүлэх болно.
- 7 Тэрээр хавчигдсан байна, мөн тэрээр зовоогдсон байна, гэвч тэрээр ам нээх нь үгүй; нядалгааны газар тэр хурга мэт авчрагдан, мөн ноос хяргагчийн өмнө хонь хэлгүй байдаг мэт, тэрчлэн тэрээр ам үл нээх болно.
- 8 Тэрээр шоронгоос мөн шүүлтээс авагдсан буюу; мөн хэн түүний үе удмыг тунхаглах билээ? Учир нь тэрээр амьдын ертөнцөөс тусгаарлагдсан байв; тэрээр миний хүмүүсийн зөрчлүүдийн улмаас зовсон бөлгөө.
- 9 Мөн тэрээр өөрийн булшийг ёс бусыг үйлдэгчидтэй нэг дор байлгав, мөн үхэлдээ баячуудтай нэг дор байв; тэрбээр хилэнц үйлдсэнгүйн учир, мөн түүний аманд заль мэх байсангүйн учир буюу.

## Mosiah 14

Yea, even doth not Isaiah say: Who hath believed our report, and to whom is the arm of the Lord revealed?

For he shall grow up before him as a tender plant, and as a root out of dry ground; he hath no form nor comeliness; and when we shall see him there is no beauty that we should desire him.

He is despised and rejected of men; a man of sorrows, and acquainted with grief; and we hid as it were our faces from him; he was despised, and we esteemed him not.

Surely he has borne our griefs, and carried our sorrows; yet we did esteem him stricken, smitten of God, and afflicted.

But he was wounded for our transgressions, he was bruised for our iniquities; the chastisement of our peace was upon him; and with his stripes we are healed.

All we, like sheep, have gone astray; we have turned every one to his own way; and the Lord hath laid on him the iniquities of us all.

He was oppressed, and he was afflicted, yet he opened not his mouth; he is brought as a lamb to the slaughter, and as a sheep before her shearers is dumb so he opened not his mouth.

He was taken from prison and from judgment; and who shall declare his generation? For he was cut off out of the land of the living; for the transgressions of my people was he stricken.

And he made his grave with the wicked, and with the rich in his death; because he had done no evil, neither was any deceit in his mouth.

10 Гэвч тэрээр зодуулан хөхрөх нь Их Эзэний таалалд нийцсэн юм; тэрээр түүнийг гашуудалд умбуулсан; та нар түүний бодгалийг нүглийн төлөөс болгоход тэрээр үр удмаа харах болно, тэрээр өөрийн өдрүүдийг уртасгаж, мөн Их Эзэний таалал түүний гарт дэгжих болно.

11 Тэрээр бодгалийнхаа тарчлалыг харах болно, мөн сэтгэл хангагдах болно; миний зөв шударга үйлчлэгч олныг мэдлэгээрээ зөвтгөх болно; учир нь тэрээр тэдний алдсуудыг үүрэлцэх болно.

12 Тиймийн тул би түүнд агуу ихсүүдтэй адил хувийг оногдуулж, мөн тэрээр хүчтэнүүдтэй адил олзыг хуваалцана; учир нь тэр сүнсээ үхэх хүртлээ юүлсэн билээ; мөн тэрбээр зөрчигчидтэй хамт тоологдсон; мөн тэрээр олны нүглийг үүрэлцэж, мөн зөрчигчдэд өмгөөлөл үйлдсэн бөлгөө.

Yet it pleased the Lord to bruise him; he hath put him to grief; when thou shalt make his soul an offering for sin he shall see his seed, he shall prolong his days, and the pleasure of the Lord shall prosper in his hand.

He shall see the travail of his soul, and shall be satisfied; by his knowledge shall my righteous servant justify many; for he shall bear their iniquities.

Therefore will I divide him a portion with the great, and he shall divide the spoil with the strong; because he hath poured out his soul unto death; and he was numbered with the transgressors; and he bore the sins of many, and made intercession for the transgressors.

## Мозая 15

- 1 Мөн эдүгээ Абинадай тэдэнд хэлэв: Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирэх болно, мөн өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно гэдгийг та нар ойлгоосой хэмээнэ би.
- 2 Мөн тэрээр маханбодид оршихын учир тэрээр Бурханы Хүү гэж нэрлэгдэх болно, мөн Эцэгийн тааллын дагуу маханбодийг харьяалуулсны учир, Эцэг мөн Хүү байдаг—
- 3 Эцэг, учир нь тэр Бурханы хүчээр бий болгогдсон билээ; мөн Хүү, маханбодийнхоо учир буюу; ийн Эцэг бас Хүү болдог—
- 4 Мөн тэд бол нэг Бурхан, тийм ээ, тэнгэр ба газрын чухамхүү тэр Мөнхийн Эцэг.
- 5 Мөн тийн маханбодь Сүнсний харьяат болж, өөрөөр хэлбэл Хүү нь Эцэгийн харьяат болох учир, нэг Бурхан тул, уруу таталтыг тэвчдэг, мөн уруу таталтанд үл автагддаг, гэсэн ч өөрийгөө доромжлогдохыг, мөн цээрлүүлэгдэхийг, мөн хөөгдөхийг, мөн өөрийн хүмүүсээр эс үнэлэгдэхийг тэвчих бөлгөө.
- 6 Мөн энэ бүгдийн дараа, хүмүүний үрсийн дунд олон хүчит гайхамшиг үйлдсэнийхээ дараа, тэрээр хөтлөгдөх болно, тийм ээ, бүр Исаиагийн хэлсэнчлэн, ноос хяргагчийн өмнө хонь хэлгүй лугаа адил байдаг шиг, тэрчлэн тэрбээр амаа үл нээх болно.
- 7 Тийм ээ, бүр тийн тэр хөтлөгдөн, цовдлогдон, мөн хөнөөгдөх болно, уг маханбодь бүр үхлийн харьяат болж, Хүүгийн таалал Эцэгийн таалалд багтах бөлгөө.
- 8 Мөн Бурхан ийн үхлийн хүлээсийг тасчина, учир нь тэр үхлийг даван ялалтыг олно; мөн тэрээр Хүүд хүмүүний үрсийн төлөө өмгөөлөл хийх хүчийг өгнө—
- 9 Тэнгэрт одсон, нигүүлслийн зүрхтэй байна; мөн тэрээр хүмүүний үрсэд хандсан нинжин сэтгэлээр дүүргэгдсэн байна; мөн тэрээр тэдний мөн шударга ёсны хооронд зогсдог бөлгөө; үхлийн хүлээсийг тасчиж, өөр дээрээ тэдний алдас мөн тэдний зөрчлүүдийг авч, тэднийг гэтэлгэн, мөн шударга ёсны шаардлагыг хангах буюу.

## Mosiah 15

And now Abinadi said unto them: I would that ye should understand that God himself shall come down among the children of men, and shall redeem his people.

And because he dwelleth in flesh he shall be called the Son of God, and having subjected the flesh to the will of the Father, being the Father and the Son—

The Father, because he was conceived by the power of God; and the Son, because of the flesh; thus becoming the Father and Son—

And they are one God, yea, the very Eternal Father of heaven and of earth.

And thus the flesh becoming subject to the Spirit, or the Son to the Father, being one God, suffereth temptation, and yieldeth not to the temptation, but suffereth himself to be mocked, and scourged, and cast out, and disowned by his people.

And after all this, after working many mighty miracles among the children of men, he shall be led, yea, even as Isaiah said, as a sheep before the shearer is dumb, so he opened not his mouth.

Yea, even so he shall be led, crucified, and slain, the flesh becoming subject even unto death, the will of the Son being swallowed up in the will of the Father.

And thus God breaketh the bands of death, having gained the victory over death; giving the Son power to make intercession for the children of men—

Having ascended into heaven, having the bowels of mercy; being filled with compassion towards the children of men; standing betwixt them and justice; having broken the bands of death, taken upon himself their iniquity and their transgressions, having redeemed them, and satisfied the demands of justice.

10 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, түүний үе удмыг хэн тунхаглах билээ? Болгоогтун, би та нарт хэлье, түүний бодгаль нүглийн төлөөс болсон байхад тэрээр өөрийн үрсийг харах болно. Мөн эдүгээ та нар юу хэлэх вэ? Мөн хэн түүний үр удам байх билээ

11 Болгоогтун би та нарт хэлнэ, бошиглогчдын үгсийг сонссон хэн боловч, тийм ээ, Их Эзэний ирэлтийн талаар бошиглосон бүх ариун бошиглогчид— би та нарт хэлнэ, тэдний үгсийг сонсож анхаарсан хэн боловч бүгд мөн Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэх болно хэмээн итгэсэн, мөн нүглүүдийнхээ ангижралын төлөө тэр өдрийг харуулдан хүлээсэн нь, би та нарт хэлье, эд бол түүний үр удам, өөрөөр хэлбэл тэд бол Бурханы хаант улсыг өвлөгчид юм.

12 Учир нь тэрээр нүглийг нь үүрсэн тэд бол эдгээр болой; эдгээр нь өөрсдийнх нь зөрчлүүдээс тэднийг гэтэлгэхийн тулд наснаас хальсан тэд болой. Мөн эдүгээ, тэд түүний үр удам бус уу

13 Тийм ээ, мөн бошиглогчид ч тийм бус уу? Бошиглохын тулд амаа нээсэн болон зөрчилд унаагүй, дэлхий эхэлсэн цагаас хойших бүх ариун бошиглогчдыг би хэлж байна. Тэд бол түүний үр удам гэдгийг би та нарт хэлнэ.

14 Мөн эдгээр нь амар амгаланг зарласан тэд, сайны тухай баярт мэдээг авчирсан тэд, авралыг зарласан тэд бөлгөө; мөн Сионд хэлсэн нь: Таны Бурхан хаанчлан буй!

15 Мөн, Ай уулсын дээрх тэдний хөл хичнээн үзэсгэлэнтэй байсан билээ!

16 Мөн түүнчлэн, амар амгаланг зарласаар буй тэдний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ!

17 Мөн түүнчлэн, хожим амар амгаланг зарлах тэдний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ, тийм ээ, энэ цагаас хойшид мөн үүрд!

18 Мөн болгоогтун, би та нарт хэлье, энэ бол бүгд биш. Учир нь амар амгаланг үндэслэгч нь болсон тэр, баярт мэдээг авчрах түүний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ, тийм ээ, бүр Их Эзэн, өөрийн хүмүүсийг гэтэлгэсэн тэрбээр; тийм ээ, өөрийн хүмүүст авралыг хайрласан тэрбээр;

And now I say unto you, who shall declare his generation? Behold, I say unto you, that when his soul has been made an offering for sin he shall see his seed. And now what say ye? And who shall be his seed?

Behold I say unto you, that whosoever has heard the words of the prophets, yea, all the holy prophets who have prophesied concerning the coming of the Lord—I say unto you, that all those who have hearkened unto their words, and believed that the Lord would redeem his people, and have looked forward to that day for a remission of their sins, I say unto you, that these are his seed, or they are the heirs of the kingdom of God.

For these are they whose sins he has borne; these are they for whom he has died, to redeem them from their transgressions. And now, are they not his seed?

Yea, and are not the prophets, every one that has opened his mouth to prophesy, that has not fallen into transgression, I mean all the holy prophets ever since the world began? I say unto you that they are his seed.

And these are they who have published peace, who have brought good tidings of good, who have published salvation; and said unto Zion: Thy God reigneth!

And O how beautiful upon the mountains were their feet!

And again, how beautiful upon the mountains are the feet of those that are still publishing peace!

And again, how beautiful upon the mountains are the feet of those who shall hereafter publish peace, yea, from this time henceforth and forever!

And behold, I say unto you, this is not all. For O how beautiful upon the mountains are the feet of him that bringeth good tidings, that is the founder of peace, yea, even the Lord, who has redeemed his people; yea, him who has granted salvation unto his people;

19 Учир нь өөрийн хүмүүсийн төлөө түүний хийсэн, дэлхийн үүслээс бэлтгэгдсэн тэрхүү гэтэлгэл үгүй байсан аваас, би та нарт хэлнэ, энэ нь үгүй байсан аваас, бүх хүн төрөлхтөн мөхөх ёстой байсан бөлгөө.

20 Гэвч болгоогтун, үхлийн хүлээс тасчигдах болно, мөн Хүү хаанчилна, мөн үхэгсдийн дээр хүчтэй байх буюу; тиймийн тул, тэрээр үхэгсдийн амилуулалтыг улируулан тохиолгох бөлгөө.

21 Мөн амилуулалт ирнэ, бүр анхны амилуулалт; тийм ээ, бүр байсны, байгаагийн, бүр Христийн амилуулалтыг хүртэл байх тэдний амилуулалт— учир нь тийн тэрээр нэрлэгдэх бөлгөө.

22 Мөн эдүгээ, бүх бошиглогчдын мөн тэдний үгсэд итгэсэн тэд бүгдийн, өөрөөр хэлбэл Бурханы зарлигуудыг дагасан тэд бүгдийн амилуулалт, анхны амилуулалтаар босч ирэх болно; тиймийн тул, тэд бол анхны амилуулалт юм.

23 Тэд өөрсдийг нь гэтэлгэсэн Бурхантай хамт оршихоор өргөмжлөгддөг буюу; тийн үхлийн хүлээсийг тасчсан Христээр дамжин тэд мөнх амьдралтай болох болно.

24 Мөн тэд бол анхны амилуулалтанд байр эзлэх тэд болой; мөн тэд бол Христийг ирэхээс өмнө, өөрсдийн мэдэхгүйд, аврал тэдэнд тунхаглагдаагүйгээр нас барсан тэд бөлгөө. Мөн тийн Их Эзэн тэдний сэргээлтийг авчрах болно; мөн тэд анхны амилуулалтанд байр эзэлж өөрөөр хэлбэл мөнх амьдралтай байна, учир нь тэд Их Эзэнээр гэтэлгэгдсэн болой.

25 Мөн түүнчлэн бяцхан хүүхдүүдэд мөнх амьдрал буй.

26 Гэвч болгоогтун, мөн эмээгтүн, мөн Бурханы өмнө чичрэгтүн, учир нь та нар чичрэх нь зохистой; учир нь Их Эзэн өөрийг нь эсэргүүцэх мөн нүглүүддээ үхэх хэнийг боловч үл гэтэлгэнэ; тийм ээ, бүр дэлхий эхэлснээс хойш нүгэлдээ мөхсөн тэд, Бурханыг санаагайгаар эсэргүүцсэн тэд, Бурханы зарлигуудыг мэдэх мөртлөө, тэдгээрийг дагахгүй байсан тэд бүгд; тэд бол анхны амилуулалтанд байр эзлэхгүй тэд болой.

For were it not for the redemption which he hath made for his people, which was prepared from the foundation of the world, I say unto you, were it not for this, all mankind must have perished.

But behold, the bands of death shall be broken, and the Son reigneth, and hath power over the dead; therefore, he bringeth to pass the resurrection of the dead.

And there cometh a resurrection, even a first resurrection; yea, even a resurrection of those that have been, and who are, and who shall be, even until the resurrection of Christ—for so shall he be called.

And now, the resurrection of all the prophets, and all those that have believed in their words, or all those that have kept the commandments of God, shall come forth in the first resurrection; therefore, they are the first resurrection.

They are raised to dwell with God who has redeemed them; thus they have eternal life through Christ, who has broken the bands of death.

And these are those who have part in the first resurrection; and these are they that have died before Christ came, in their ignorance, not having salvation declared unto them. And thus the Lord bringeth about the restoration of these; and they have a part in the first resurrection, or have eternal life, being redeemed by the Lord.

And little children also have eternal life.

But behold, and fear, and tremble before God, for ye ought to tremble; for the Lord redeemeth none such that rebel against him and die in their sins; yea, even all those that have perished in their sins ever since the world began, that have wilfully rebelled against God, that have known the commandments of God, and would not keep them; these are they that have no part in the first resurrection.

- 27 Тиймийн тул та нар чичрэх нь зохистой бус уу?  
Учир нь аврал иймүүдийн нэгэнд нь ч ирэхгүй; учир  
нь Их Эзэн иймүүдийн нэгийг нь ч гэтэлгээгүй;  
тийм ээ, Их Эзэн иймүүдийг гэтэлгэж чадахгүй;  
учир нь тэр өөрийгөө үгүйсгэж чадахгүй; учир нь  
шударга ёс эрхээ эдлэх үед тэрээр үүнийг үгүйсгэж  
чадахгүй.
- 28 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, Их Эзэний аврал бүх  
үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст тунхаглагдах  
тэр цаг ирэх болно.
- 29 Тийм ээ, Их Эзэн, таны харуулууд дуу хоолойгоо  
өргөн; тэд нэгэн дуу хоолойгоор хамтдаа дуулах бол-  
но; учир нь тэд Их Эзэн Сионыг дахин авчрахыг нү-  
дээр үзэх болно.
- 30 Баясацгаа, хамтдаа дуулдгаа, Иерусалимын эзгүй  
газрууд аа; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайт-  
гаруулсан, тэрээр Иерусалимыг гэтэлгэсэн бөлгөө.
- 31 Их Эзэн ариун мутраа бүх үндэстнүүдийн нүдэнд  
харуулна; мөн газар дэлхийн бүх хязгаарууд бидний  
Бурханы авралыг харах болно.

Therefore ought ye not to tremble? For salvation  
cometh to none such; for the Lord hath redeemed none  
such; yea, neither can the Lord redeem such; for he can-  
not deny himself; for he cannot deny justice when it has  
its claim.

And now I say unto you that the time shall come that  
the salvation of the Lord shall be declared to every na-  
tion, kindred, tongue, and people.

Yea, Lord, thy watchmen shall lift up their voice;  
with the voice together shall they sing; for they shall see  
eye to eye, when the Lord shall bring again Zion.

Break forth into joy, sing together, ye waste places of  
Jerusalem; for the Lord hath comforted his people, he  
hath redeemed Jerusalem.

The Lord hath made bare his holy arm in the eyes of  
all the nations; and all the ends of the earth shall see the  
salvation of our God.

## Мозая 16

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор Абинадай эдгээр үгийг ярьсныхаа дараа тэр гараа урагш сунган мөн хэлэв: Бүгд Их Эзэний авралыг харна; үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс бүгд нүдээрээ үзнэ, мөн Бурханы өмнө түүний шүүлтүүд шударгыг хүлээх тэр цаг ирэх болно.
- 2 Мөн тэгээд ёсон бусыг үйлдэгчид зайлуулагдаж, мөн тэд гаслах, мөн уйлах, мөн орилох, мөн шүдээ хавирах шалтгаан бүхий болно; мөн тэд Их Эзэний дуу хоолойг анхааран сонсохгүй байсны учир бөлгөө; тиймийн тул Их Эзэн тэднийг гэтэлгэх нь үгүй.
- 3 Учир нь тэд эгэл мөн чөтгөр мэт, мөн чөтгөр тэднийг давах хүчтэй; тийм ээ, бүр бидний анхны эцэг эхийг мэхэлсэн, тэднийг уналтанд хүргэсэн тэр хөгшин хорт могой; бүх хүн төрөлхтний маханбодийг эгэл, тачаангуй, чөтгөр мэт, сайнаас мууг ялгаж мэдэх болгосны, өөрсдийгөө чөтгөрийн харьяат болгосны шалтгаан байсан тэр буюу.
- 4 Тийн бүх хүн төрөлхтөн төөрөлдсөн бөлгөө; мөн болгоогтун, Бурхан өөрийнхөө хүмүүсийг төөрөлдсөн мөн унасан байдлаас нь гэтэлгээгүй сэн бол тэд төгсгөлгүйгээр төөрөлдөх байсан буйза.
- 5 Гэвч өөрийн эгэл чанартаа хэвээр үлдэж мөн нүглийн хийгээд Бурханыг эсэргүүцэх замуудаар явсаар байдаг тэрээр, унасан байдалдаа үлдэж мөн чөтгөр түүнийг давах бүхий л хүчтэй байна. Тиймийн тул тэрээр гэтэлгэл хийгдсэнгүй мэт, Бурханы дайсан байдаг учир; мөн түүнчлэн чөтгөр бол Бурханы дайсан бөлгөө.
- 6 Мөн эдүгээ хэрэв Христ дэлхийд ирээгүй аваас, ирэх зүйлүүдийг аль хэдийн ирсэн мэт яривал, гэтэлгэл байж чадахгүй сэн билээ.
- 7 Мөнхүү хэрэв Христ үхэгсдийн дундаас босоогүй сэн бол, өөрөөр хэлбэл булш нь ялалт үгүй байж мөн үхэл нь гашуун бус байхын учир, үхлийн хүлээсийг тасчаагүй сэн бол, амилуулалт гэж үгүй байх сан.
- 8 Гэвч амилуулалт буй, тиймийн тул булшинд ялалт гэж үгүй, мөн үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм.

## Mosiah 16

And now, it came to pass that after Abinadi had spoken these words he stretched forth his hand and said: The time shall come when all shall see the salvation of the Lord; when every nation, kindred, tongue, and people shall see eye to eye and shall confess before God that his judgments are just.

And then shall the wicked be cast out, and they shall have cause to howl, and weep, and wail, and gnash their teeth; and this because they would not hearken unto the voice of the Lord; therefore the Lord redeemeth them not.

For they are carnal and devilish, and the devil has power over them; yea, even that old serpent that did beguile our first parents, which was the cause of their fall; which was the cause of all mankind becoming carnal, sensual, devilish, knowing evil from good, subjecting themselves to the devil.

Thus all mankind were lost; and behold, they would have been endlessly lost were it not that God redeemed his people from their lost and fallen state.

But remember that he that persists in his own carnal nature, and goes on in the ways of sin and rebellion against God, remaineth in his fallen state and the devil hath all power over him. Therefore he is as though there was no redemption made, being an enemy to God; and also is the devil an enemy to God.

And now if Christ had not come into the world, speaking of things to come as though they had already come, there could have been no redemption.

And if Christ had not risen from the dead, or have broken the bands of death that the grave should have no victory, and that death should have no sting, there could have been no resurrection.

But there is a resurrection, therefore the grave hath no victory, and the sting of death is swallowed up in Christ.

- 9 Тэр бол дэлхийн гэрэл хийгээд амь амьдрал болой; тийм ээ, хэзээ ч харанхуйлагдахгүй төгсгөлгүй тэрхүү гэрэл; тийм ээ, мөн түүнчлэн үхэл гэж цаашид байж үл болох, төгсгөлгүй амь амьдрал болой.
- 10 Бүр энэ зуурдын бие үхэшгүй байдлыг өмсөж, мөн энэ ялзрал ялзаршгүй байдалд тавигдах болно, мөн Бурханы тавцангийн өмнө зогсон, тэдгээр нь сайн ч бай, эсвэл тэдгээр нь хилэнцэт ч бай, үйлүүдийнхээ дагуу түүнд шүүгдэхээр авчрагдах болно—
- 11 Хэрэв тэдгээр нь сайн байх аваас, төгсгөлгүй амьдралын мөн аз жаргалын амилуулалтанд; мөн хэрэв тэдгээр нь хилэнцэт байх аваас төгсгөлгүй ялын амилуулалтанд, тэднийг харьяалах чөтгөрт илгээгдэх тул, ял гэдэг нь тэр буюу—
- 12 Өөрсдийн эгэл тааллууд мөн хүслүүдийн дагуу явсан учир; нигүүлслийн мутар нь тэдний зүг сунгагдсан үед Их Эзэнийг хэзээ ч дуудаагүй учир; тодруулбал нигүүлслийн мутар тэдний зүг сунгаастай байсан, мөн тэд хүссэнгүй; тэд алдсуудынхаа талаар сэрэмжлүүлэгдсэн ч, тэд тэдгээрээс хагацсан нь үгүй бөлгөө; мөн тэд наманчлахыг зарлигдуулсан боловч тэд наманчлахгүй байлаа.
- 13 Мөн эдүгээ, та нар чичирч мөн нүглээ наманчлан, мөн зөвхөн Христэд мөн түүгээр дамжуулан та нар аврагдаж чадна гэдгийг санах нь зохистой бус уу
- 14 Тиймийн тул, хэрэв та нар Мосегийн хуулийг заана гэвэл, түүнчлэн энэ нь ирэх зүйлүүдийн дүрслэл гэдгийг заагтун—
- 15 Тэдэнд гэтэлгэл нь чухам Мөнхийн Эцэг болох Христ Их Эзэнээр дамжин ирэхийг сургагтун. Амен.

He is the light and the life of the world; yea, a light that is endless, that can never be darkened; yea, and also a life which is endless, that there can be no more death.

Even this mortal shall put on immortality, and this corruption shall put on incorruption, and shall be brought to stand before the bar of God, to be judged of him according to their works whether they be good or whether they be evil—

If they be good, to the resurrection of endless life and happiness; and if they be evil, to the resurrection of endless damnation, being delivered up to the devil, who hath subjected them, which is damnation—

Having gone according to their own carnal wills and desires; having never called upon the Lord while the arms of mercy were extended towards them; for the arms of mercy were extended towards them, and they would not; they being warned of their iniquities and yet they would not depart from them; and they were commanded to repent and yet they would not repent.

And now, ought ye not to tremble and repent of your sins, and remember that only in and through Christ ye can be saved?

Therefore, if ye teach the law of Moses, also teach that it is a shadow of those things which are to come—

Teach them that redemption cometh through Christ the Lord, who is the very Eternal Father. Amen.



## Мозая 17

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Абинадай эдгээр үгээ дуусахад, санваартнууд түүнийг барьж мөн тэр үхэлд хүргэгдэх ёстой хэмээн хаан зарлиг болгосон бөлгөө.
- 2 Гэвч тэдний дунд Алма гэж нэрлэгдсэн нэгэн байв, түүнчлэн тэр Нифайн удам байлаа. Мөн тэрээр залуу хүн байж, мөн Абинадайн ярьсан үгсэд итгэжээ, учир нь тэрээр тэдний эсрэг Абинадайн гэрчилсэн алдсын талаар мэдэж байв; тиймийн тул тэрээр Абинадайд уурлахгүй байхыг, харин түүнийг амар амгалан явуулахыг зөвшөөрөхийг хаанаас гуйж эхлэв.
- 3 Гэвч хаан илүүтэй хилэгнэж, мөн Алмаг тэдний дундаас зайлуулагдах болгов, мөн тэд түүнийг алж болохын тулд зарц нараа түүний араас илгээсэн бөлгөө.
- 4 Гэвч тэр тэдний өмнө зугтан мөн өөрийгөө нуусан учир тэд түүнийг олсонгүй. Мөн тэрээр олон өдөр нуугдаж байсан учир Абинадайн ярьсан бүх үгсийг бичиглэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор хаан харуулуудаараа Абинадайг бүслүүлэн мөн баривчлуулав; тэгээд тэд түүнийг хүлж, шоронд хаяв.
- 6 Мөн гурав хоногийн дараа, санваартнуудтайгаа зөвлөсний дараа, тэрээр түүнийг өөрийнхөө өмнө дахин авчруулав.
- 7 Мөн тэрээр түүнд хэлэв: Абинадай, бид чиний эсрэг буруушаалтыг оллоо, тэгэхлээр чи үхвэл зохино.
- 8 Учир нь Бурхан өөрөө хүмүүний үрсийн дунд доош ирэх болно хэмээн чи хэлсэн; мөн эдүгээ, үүний улмаас чи миний болон миний хүмүүсийн талаар хилэнцтийг ярьсан тэр бүх үгээ буцаахгүй аваас чи үхэлд хүргэгдэх болно.
- 9 Эдүгээ Абинадай түүнд хэлэв: Би танд хэлнэ, би энэ хүмүүсийн талаар та нарт ярьсан үгсээ буцаах нь үгүй, тэдгээр нь үнэн учир; мөн та нар тэдгээрийг гарцаагүй гэдгийг мэдэж болохын тулд би өөрийгөө та нарын гарт орохыг хүлцсэн бөлгөө.

## Mosiah 17

And now it came to pass that when Abinadi had finished these sayings, that the king commanded that the priests should take him and cause that he should be put to death.

But there was one among them whose name was Alma, he also being a descendant of Nephi. And he was a young man, and he believed the words which Abinadi had spoken, for he knew concerning the iniquity which Abinadi had testified against them; therefore he began to plead with the king that he would not be angry with Abinadi, but suffer that he might depart in peace.

But the king was more wroth, and caused that Alma should be cast out from among them, and sent his servants after him that they might slay him.

But he fled from before them and hid himself that they found him not. And he being concealed for many days did write all the words which Abinadi had spoken.

And it came to pass that the king caused that his guards should surround Abinadi and take him; and they bound him and cast him into prison.

And after three days, having counseled with his priests, he caused that he should again be brought before him.

And he said unto him: Abinadi, we have found an accusation against thee, and thou art worthy of death.

For thou hast said that God himself should come down among the children of men; and now, for this cause thou shalt be put to death unless thou wilt recall all the words which thou hast spoken evil concerning me and my people.

Now Abinadi said unto him: I say unto you, I will not recall the words which I have spoken unto you concerning this people, for they are true; and that ye may know of their surety I have suffered myself that I have fallen into your hands.

10 Тийм ээ, мөн би бүр үхэлд хүртэл зовох болно, мөн би өөрийн үгсийг буцаахгүй, бас тэдгээр нь та нарын эсрэг гэрчлэл болон зогсох болно. Мөн хэрэв та нар намайг албал та нар гэмгүй цусыг урсгах болно, мөн энэ нь түүнчлэн эцсийн өдөр та нарын эсрэг гэрчлэл болж зогсох болно.

11 Мөн эдүгээ хаан Ноа түүний үгнээс айсан учир түүнийг суллах дөхөв; учир нь Бурханы шүүлтүүд өөр дээр нь ирэх вий хэмээн тэр айсан ажээ.

12 Гэвч санваартнууд түүний эсрэг дуугаа өндөрсгөн, мөн түүнийг буруутгаж эхлэв, өгүлсэн нь: Тэр хааныг доромжилсон. Тиймийн тул хаан түүний эсрэг уурандаа бачуурч, мөн тэрээр түүнийг хөнөөгдөж болохын тулд илгээв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг барьж мөн хүлээд, мөн арьсыг нь саваагаар, тийм ээ, бүр үхтэл нь ороолгов.

14 Мөн эдүгээ дөл түүнийг түлж эхлэхэд, тэрээр тэнд хашгирч, өгүүлсэн нь:

15 Болгоогтун, та нар намайг ингэсний тань адил, үүнчлэн улиран тохиох дор та нарын үр удам миний тэвчсэн өвчнийг, бүр галд шатаагдаж үхэхийн зовлонг олонд мэдрүүлэх болно; мөн тэд Их Эзэн Бурханыхаа авралд итгэдэг учраас болой.

16 Мөнхүү улиран тохиох дор та нар алдсуудынхаа улмаас төрөл бүрийн өвчний улмаас зовоогдох болно.

17 Тийм ээ, мөн та нар тал бүрээсээ цохигдох болно, мөн нааш цааш бусниулагдаж мөн туугдах болно, бүр зэрлэг мөн догшин араатнуудад зэрлэг сүрэг туугддаг лугаа адил байх болно.

18 Мөн тэр өдөр та нар ангуучлагдах болно, мөн та нар дайснуудынхаа гараар баривчлагдах болно, мөн тэгээд та нар зовж, миний зовж буйн адил, шатаагдан үхэхийн өвдөлтөөр зовох болно.

19 Ийн Бурхан өөрийнх нь хүмүүсийг устгах тэдний дээр өс хонзонгоо хэрэгжүүлдэг болой. Ай Бурхан минь, бодгалийг минь хүлээн аваач.

20 Мөн эдүгээ, Абинадай эдгээр үгийг хэлээд, тэр унав, шатаагдаж үхэхийн зовлонг амссан ажгуу; тийм ээ, тэрээр Бурханы зарлигуудыг үгүйсгэхгүйн тулд үхэлд тушаагдсан байв, өөрийн үгсийн үнэнийг амиараа лацдан баталжээ.

Yea, and I will suffer even until death, and I will not recall my words, and they shall stand as a testimony against you. And if ye slay me ye will shed innocent blood, and this shall also stand as a testimony against you at the last day.

And now king Noah was about to release him, for he feared his word; for he feared that the judgments of God would come upon him.

But the priests lifted up their voices against him, and began to accuse him, saying: He has reviled the king. Therefore the king was stirred up in anger against him, and he delivered him up that he might be slain.

And it came to pass that they took him and bound him, and scourged his skin with faggots, yea, even unto death.

And now when the flames began to scorch him, he cried unto them, saying:

Behold, even as ye have done unto me, so shall it come to pass that thy seed shall cause that many shall suffer the pains that I do suffer, even the pains of death by fire; and this because they believe in the salvation of the Lord their God.

And it will come to pass that ye shall be afflicted with all manner of diseases because of your iniquities.

Yea, and ye shall be smitten on every hand, and shall be driven and scattered to and fro, even as a wild flock is driven by wild and ferocious beasts.

And in that day ye shall be hunted, and ye shall be taken by the hand of your enemies, and then ye shall suffer, as I suffer, the pains of death by fire.

Thus God executeth vengeance upon those that destroy his people. O God, receive my soul.

And now, when Abinadi had said these words, he fell, having suffered death by fire; yea, having been put to death because he would not deny the commandments of God, having sealed the truth of his words by his death.

## Мозая 18

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор хаан Ноагийн зарц нараас зугтсан Алма, өөрийн нүглүүд хийгээд алдсуудаа наманчлав, мөн хүмүүсийн дунд нууцаар орон явж, Абинадайн үгсийг сургаж эхлэв—
- 2 Тийм ээ, ирэх зүйлүүдийн талаар, мөн түүнчлэн Христийн хүч чадал, мөн тарчлал, мөн үхлээр, мөн түүний амилалт мөн тэнгэрт дээшлэн одсоноор тохиосон үхэгсдийн амилуулалтын, мөн хүмүүсийн гэтэлгэлийн талаар буюу.
- 3 Мөн түүний үгийг анхааран сонсох болгонд тэрээр сургасан болой. Мөн тэрээр энэ нь хаанд мэдэгдэж болохгүйн тулд, тэдэнд нууцаар сургажээ. Мөн олон нь түүний үгсэд итгэв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор нэрээ тэндээс хүртсэн, мөн энэ нь нутгийн хязгаар бөгөөд цаг улирлаар зэрлэг амьтад хөлхөлдсөн Мормон гэж нэрлэгдсэн нутагт түүнд итгэсэн болгон очиж байв.
- 5 Эдүгээ, Мормонд цэвэр устай булаг байв, мөн усны дэргэд өдрийн цагт хааны эрлээс тэрээр өөрийгөө далдлан нуудаг байсан багахан төгөл байсан тул Алма тэнд очиж хоргодсон бөлгөө.
- 6 Мөнхүү улиран тохиох дор түүнд итгэсэн болгон түүний үгсийг сонсохоор тийш одож байв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор олон өдрийн дараа нилээд тооны хүмүүс Алмагийн үгсийг сонсохоор Мормоны нутагт цугларцгаав. Тийм ээ, түүний үгэнд итгэсэн бүгд түүнийг сонсохоор цугларсан байлаа. Мөн тэрээр тэдэнд сургаж, мөн тэдэнд наманчлал, гэтэлгэл, мөн Их Эзэнд итгэх итгэлийг номлосон ажээ.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, Мормоны Ус энэ байна (учир нь энэ нь тийн нэрлэгдсэн байв) мөн эдүгээ, та нар Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, үүрэлцэхэд бэлэн байв;

## Mosiah 18

And now, it came to pass that Alma, who had fled from the servants of king Noah, repented of his sins and iniquities, and went about privately among the people, and began to teach the words of Abinadi—

Yea, concerning that which was to come, and also concerning the resurrection of the dead, and the redemption of the people, which was to be brought to pass through the power, and sufferings, and death of Christ, and his resurrection and ascension into heaven.

And as many as would hear his word he did teach. And he taught them privately, that it might not come to the knowledge of the king. And many did believe his words.

And it came to pass that as many as did believe him did go forth to a place which was called Mormon, having received its name from the king, being in the borders of the land having been infested, by times or at seasons, by wild beasts.

Now, there was in Mormon a fountain of pure water, and Alma resorted thither, there being near the water a thicket of small trees, where he did hide himself in the daytime from the searches of the king.

And it came to pass that as many as believed him went thither to hear his words.

And it came to pass after many days there were a goodly number gathered together at the place of Mormon, to hear the words of Alma. Yea, all were gathered together that believed on his word, to hear him. And he did teach them, and did preach unto them repentance, and redemption, and faith on the Lord.

And it came to pass that he said unto them: Behold, here are the waters of Mormon (for thus were they called) and now, as ye are desirous to come into the fold of God, and to be called his people, and are willing to bear one another's burdens, that they may be light;

9 Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлний учир, мөнх амьдралыг авч болохын тулд, Бурханаар гэтэлгэгдэж, мөн та нар анхны амилуулалтын тэдний дунд тоологдож болохын тулд буюу—

10 Эдүгээ би та нарт хэлнэ, хэрэв энэ нь та нарын зүрхний хүслэн байх аваас, тэр өөрийн Сүнсийг та нар дээр илүү элбэгээр юүлж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн гэрээ байгуулснаа түүний өмнө гэрчилж, Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ

11 Мөн эдүгээ хүмүүс эдгээр үгийг дуулаад, тэд баярласнаас алгаа ташин, мөн ийн хашгираа: Энэ бол бидний зүрхний хүслэн билээ.

12 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма, анхны хэдийн нэг байсан Хеламыг авч, мөн явж усан дотор зогсоод, мөн хашгирч, хэлсэн нь: Ай Их Эзэн, тэрээр энэ ажлыг зүрх сэтгэлийн ариунаар хийж болохын тулд өөрийн Сүнсийг та үйлчлэгчийнхээ дээр юүлээч.

13 Мөн эдгээр үгийг хэлэхэд, Их Эзэний Сүнс түүн дээр байв, мөн тэр хэлэв: Хелам, Бүхнийг Чадагч Бурханаас эрх мэдлийг хүлээн авсны учир, та зуурдын биеэ үхэн үхтэл түүнд үйлчлэхээр түүнтэй гэрээ байгуулж буйг гэрчлэн би танд баптисм хүртээв; мөн Их Эзэний Сүнс тан дээр юүлэгдэг; мөн тэрээр дэлхийн үүслээс бэлтгэгдсэн Христийн гэтэлгэлээр дамжуулан танд мөнх амьдралыг соёрхох болтугай.

14 Мөн Алма эдгээр үгсийг хэлсний дараа, Алма Хелам хоёул усанд бүрхэгдэв; мөн тэд босож, мөн тэд Сүнсээр дүүргэгдсэн учир уснаас баясан гарч ирэв.

15 Мөн түүнчлэн, Алма өөр нэгийг авч, мөн хоёрдахь удаагаа усанд ороод, мөн түүнд эхний адилаар баптисм хүртээв, зөвхөн тэр өөрийгөө дахин усанд дүрсэнгүй.

Yea, and are willing to mourn with those that mourn; yea, and comfort those that stand in need of comfort, and to stand as witnesses of God at all times and in all things, and in all places that ye may be in, even until death, that ye may be redeemed of God, and be numbered with those of the first resurrection, that ye may have eternal life—

Now I say unto you, if this be the desire of your hearts, what have you against being baptized in the name of the Lord, as a witness before him that ye have entered into a covenant with him, that ye will serve him and keep his commandments, that he may pour out his Spirit more abundantly upon you?

And now when the people had heard these words, they clapped their hands for joy, and exclaimed: This is the desire of our hearts.

And now it came to pass that Alma took Helam, he being one of the first, and went and stood forth in the water, and cried, saying: O Lord, pour out thy Spirit upon thy servant, that he may do this work with holiness of heart.

And when he had said these words, the Spirit of the Lord was upon him, and he said: Helam, I baptize thee, having authority from the Almighty God, as a testimony that ye have entered into a covenant to serve him until you are dead as to the mortal body; and may the Spirit of the Lord be poured out upon you; and may he grant unto you eternal life, through the redemption of Christ, whom he has prepared from the foundation of the world.

And after Alma had said these words, both Alma and Helam were buried in the water; and they arose and came forth out of the water rejoicing, being filled with the Spirit.

And again, Alma took another, and went forth a second time into the water, and baptized him according to the first, only he did not bury himself again in the water.

- 16 Мөн энэ маягаар тэр Мормоны нутагт ирсэн болгонд баптисм хүртээв; мөн тэд тоогоор бараг хоёр зуун дөрвөн бодгаль байв; тийм ээ, мөн тэд Мормоны усанд баптисм хүртэж, Бурханы ач ивээлээр дүүргэгдсэн байв.
- 17 Мөн тэд тэр цагаас Бурханы сүм буюу Христийн сүм гэж нэрлэгдэв. Мөнхүү улиран тохиох дор Бурханы хүч болон эрх мэдлээр баптисм хүртсэн хэн боловч түүний сүмд нэмэгдэж байв.
- 18 Мөнхүү улиран тохиох дор Алма, Бурханаас эрх мэдэл хүлээн авсан тул, санваартнуудыг томилов; бүр тэдний тавь тутамд тэдэнд номлох, мөн тэдэнд Бурханы хаант улсад хамаатай зүйлүүдийн талаар сургах нэг санваартныг тэрээр томилсон бөлгөө.
- 19 Мөн тэрээр тэд өөрийнх нь заасан, мөн ариун бошиглогчдын амаар яригдсанаас өөр юуг ч тэд заах ёсгүй хэмээн тэдэнд зарлиг буулгав.
- 20 Тийм ээ, бүр тэрээр тэд наманчлал түүнчлэн өөрийн хүмүүсийг гэтэлгэсэн Их Эзэнд итгэх итгэлээс өөр юуг ч номлох ёсгүйг тэдэнд зарлиг болгов.
- 21 Мөн тэрээр тэдний өөр хооронд зөрчилдөөн байх ёсгүй, харин нэг итгэл мөн нэг баптисмтай байж, зүрх сэтгэлээ эв нэгдэл хийгээд нэг нэгнийхээ зүг хандсан хайранд нэгтгэн тэд нэг нүдээр урагш харах ёстой хэмээн тэдэнд зарлиг болгов.
- 22 Мөн ийн тэр тэдэнд номлохыг зарлиглав. Мөн тийн тэд Бурханы хүүхдүүд болов.
- 23 Мөн тэд хүндэтгэлийн өдрийг сахьж, мөн үүнийг ариун байлгах, мөн түүнчлэн өдөр бүр тэд Их Эзэн Бурхандаа талархлаа илэрхийлэх ёстойг тэрээр тэдэнд зарлиг болгов.
- 24 Мөн түүнчлэн тэрээр түүний томилсон санваартнууд өөрсдийн гараар хөдөлмөрлөж өөрсдийгөө тэжээх ёстой хэмээн тэдэнд зарлиг болгов.
- 25 Мөн тэд хүмүүст зааж, мөн Их Эзэн Бурханаа шүтэхээр нэгдэн цугларах ёстой долоо хоног бүрийн нэг өдөр мөн түүнчлэн, өөрсдийн боломжоор ойр ойрхон чуулахаар тогтоогдов.

And after this manner he did baptize every one that went forth to the place of Mormon; and they were in number about two hundred and four souls; yea, and they were baptized in the waters of Mormon, and were filled with the grace of God.

And they were called the church of God, or the church of Christ, from that time forward. And it came to pass that whosoever was baptized by the power and authority of God was added to his church.

And it came to pass that Alma, having authority from God, ordained priests; even one priest to every fifty of their number did he ordain to preach unto them, and to teach them concerning the things pertaining to the kingdom of God.

And he commanded them that they should teach nothing save it were the things which he had taught, and which had been spoken by the mouth of the holy prophets.

Yea, even he commanded them that they should preach nothing save it were repentance and faith on the Lord, who had redeemed his people.

And he commanded them that there should be no contention one with another, but that they should look forward with one eye, having one faith and one baptism, having their hearts knit together in unity and in love one towards another.

And thus he commanded them to preach. And thus they became the children of God.

And he commanded them that they should observe the sabbath day, and keep it holy, and also every day they should give thanks to the Lord their God.

And he also commanded them that the priests whom he had ordained should labor with their own hands for their support.

And there was one day in every week that was set apart that they should gather themselves together to teach the people, and to worship the Lord their God, and also, as often as it was in their power, to assemble themselves together.

26 Мөн санваартнууд өөрсдийгөө тэтгэхийн тулд хүмүүс дээр түшиглэх биш; харин хөдөлмөрийнхөө хариуд Бурханы ач ивээлийг авах байсан, тэд Бурханаас хүлээн авсан хүчтэйгээр мөн эрх мэдэлтэйгээр сургаж болохын тулд, Бурханы мэдлэгтэй байж Сүнсэнд хүчтэй болж болохын тулд бөлгөө.

27 Мөн түүнчлэн сүмийн хүмүүс хөрөнгөнөөсөө, хүн бүр өөрт байгаагийнхаа хэрээр өглөг хуваалцвал зохино; хэрэв түүнд илүү их хөрөнгө байваас илүү ихийг хуваалцах ёстой; мөн харин түүнд бага байвал, түүнээс багыг л шаардах ёстой; мөн юмгүй түүнд өгөгдөх ёстой хэмээн Алма зарлиг болгов.

28 Мөн тийн тэд өөрсдийн чөлөөт хүсэл, мөн Бурханд хандах сайн хүслийн учир, мөн гачигдах болсон тэдгээр санваартнуудад, тийм ээ, мөн гачигдалтай болгонд, нүцгэн бодгаль бүрд хөрөнгөнөөсөө өглөг болговол зохино.

29 Мөн Бурханаар зарлигдуулсны учир, тэр үүнийг тэдэнд хэлэв; мөн нэг нэгэндээ тэдний гачигдал мөн тэдний хүслийн дагуу биеийн мөн сүнсний аль алиных нь тусламжийг өгөн тэд Бурханы өмнө шударгаар алхаж байв.

30 Мөн эдүгээ улиран тохиох дор энэ бүгд Мормон нутагт хийгдэв, тийм ээ, Мормоны Усны ойролцоо, Мормоны Усны дэргэдэх төгөлд бөлгөө; тийм ээ, Мормоны нутаг, Мормоны Ус, Мормоны төгөл, тэнд Гэтэлгэгчийнхээ мэдлэгт ирсэн тэдний нүдэнд тэдгээр нь хичнээн үзэсгэлэнтэй билээ; тийм ээ, мөн тэд ямар их адислагдсан билээ, учир нь тэд үүрд түүнийг магтан дуулах болно.

31 Мөн эдгээр зүйлүүд, тэдгээр нь хаанд мэдэгдэж болохгүйн тулд нутгийн хязгаарт болсон аж.

32 Гэвч болгоогтун, улиран тохиох дор хаан, хүмүүсийн дундах хөдөлгөөнийг олж мэдээд, тэднийг тандуулахаар зарц нараа илгээв. Тиймийн тул Их Эзэний үгийг дуулахаар нэгдэн цугларцгаасан тэр өдрөө тэд хаанд мэдэгдэв.

33 Мөн эдүгээ Алма түүнийг эсэргүүцүүлэхээр хүмүүсийг өдөөн хатгаж байна хэмээн хаан хэлэв; тиймийн тул тэрээр тэднийг устгахаар их цэргээ илгээв.

And the priests were not to depend upon the people for their support; but for their labor they were to receive the grace of God, that they might wax strong in the Spirit, having the knowledge of God, that they might teach with power and authority from God.

And again Alma commanded that the people of the church should impart of their substance, every one according to that which he had; if he have more abundantly he should impart more abundantly; and of him that had but little, but little should be required; and to him that had not should be given.

And thus they should impart of their substance of their own free will and good desires towards God, and to those priests that stood in need, yea, and to every needy, naked soul.

And this he said unto them, having been commanded of God; and they did walk uprightly before God, imparting to one another both temporally and spiritually according to their needs and their wants.

And now it came to pass that all this was done in Mormon, yea, by the waters of Mormon, in the forest that was near the waters of Mormon; yea, the place of Mormon, the waters of Mormon, the forest of Mormon, how beautiful are they to the eyes of them who there came to the knowledge of their Redeemer; yea, and how blessed are they, for they shall sing to his praise forever.

And these things were done in the borders of the land, that they might not come to the knowledge of the king.

But behold, it came to pass that the king, having discovered a movement among the people, sent his servants to watch them. Therefore on the day that they were assembling themselves together to hear the word of the Lord they were discovered unto the king.

And now the king said that Alma was stirring up the people to rebellion against him; therefore he sent his army to destroy them.

34 Мөнхүү улиран тохиох дор Алмад мөн Их  
Эзэний хүмүүст хааны их цэрэг ирж буй талаар мэдэгдэв; тиймийн тул тэд майхнуудаа мөн гэр бүлээ авч аглаг буйд тийш одов.

35 Мөн тэд тоогоороо дөрвөн зуун тавь орчим бодгаль байсан бөлгөө.

And it came to pass that Alma and the people of the Lord were apprised of the coming of the king's army; therefore they took their tents and their families and departed into the wilderness.

And they were in number about four hundred and fifty souls.

## Мозая 19

- 1 Мөнхүү улиран тохиох дор хааны их цэрэг Их Эзэний хүмүүсийг үр ашиггүй хайсны эцэст эргэж ирэв.
- 2 Мөн эдүгээ болгоогтун, хааны цэргийн хүчин бага байж, цөөрсний учир болой, мөн үлдсэн хүмүүсийн дунд хагарал гарч эхлэв.
- 3 Мөн бага хэсэг нь хааны эсрэг сүрдүүлэх үг хэлж эхлээд, мөн тэдний дунд агуу зөрчилдөөн бий болж эхэллээ.
- 4 Мөн эдүгээ тэдний дунд Гидеон гэгч эр байв, мөн тэр хүчтэй мөн хааны дайсан байсан учир, тиймийн тул тэр илдээ сугалж, мөн хилэгнэсэндээ хааныг хөнөөнө хэмээн андгайлав.
- 5 Мөнхүү улиран тохиох дор тэр хаантай тулалдав; мөн тэрээр өөрийг нь хүчээр давамгайлах дөхсөнийг хаан хараад, тэрээр зугтаж мөн ариун сүмийн дэргэдэх цамхаг өөд гүйж гарав.
- 6 Мөн Гидеон түүний араас мөрдөж мөн хааныг хөнөөхөөр цамхагт гарахаар зэхэв, мөн хаан Шимлон нутгийн зүг хараа бэлчээсэнд, мөн болгоогтун, леменчүүдийн их цэрэг нутгийн хил даван ирсэн байлаа.
- 7 Мөн эдүгээ хаан сэтгэлийн тарчлалдаа бахардан хашгирч, өгүүлсэн нь: Гидеон, намайг хэлтрүүлээч, учир нь леменчүүд бидний дээр байна, мөн тэд биднийг устгах болно; тийм ээ, тэд хүмүүсийг минь устгах болно.
- 8 Мөн эдүгээ хаан амиа бодсон шигээ хүмүүсийнхээ талаар тэгж их шаналсангүй; гэсэн хэдий ч, Гидеон түүний амийг хэлтрүүлэв.
- 9 Мөн тэд леменчүүдийн өмнө зугтах ёстой хэмээн хаан хүмүүст зарлиглаж, мөн тэр өөрөө тэдний өмнө явав, мөн тэд эмэгтэйчүүд мөн хүүхдүүдтэйгээ хамт аглаг буйд тийш зугтав.
- 10 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэднийг мөрдсөн аж, мөн тэднийг гүйцэж, мөн тэднийг хөнөөж эхлэв.
- 11 Эдүгээ улиран тохиох дор хаан бүх эрсийг эхнэр, хүүхдүүдээ орхиж, мөн леменчүүдийн өмнө зугтахыг тэдэнд зарлиг болгов.

## Mosiah 19

And it came to pass that the army of the king returned, having searched in vain for the people of the Lord.

And now behold, the forces of the king were small, having been reduced, and there began to be a division among the remainder of the people.

And the lesser part began to breathe out threatenings against the king, and there began to be a great contention among them.

And now there was a man among them whose name was Gideon, and he being a strong man and an enemy to the king, therefore he drew his sword, and swore in his wrath that he would slay the king.

And it came to pass that he fought with the king; and when the king saw that he was about to overpower him, he fled and ran and got upon the tower which was near the temple.

And Gideon pursued after him and was about to get upon the tower to slay the king, and the king cast his eyes round about towards the land of Shemlon, and behold, the army of the Lamanites were within the borders of the land.

And now the king cried out in the anguish of his soul, saying: Gideon, spare me, for the Lamanites are upon us, and they will destroy us; yea, they will destroy my people.

And now the king was not so much concerned about his people as he was about his own life; nevertheless, Gideon did spare his life.

And the king commanded the people that they should flee before the Lamanites, and he himself did go before them, and they did flee into the wilderness, with their women and their children.

And it came to pass that the Lamanites did pursue them, and did overtake them, and began to slay them.

Now it came to pass that the king commanded them that all the men should leave their wives and their children, and flee before the Lamanites.



12 Эдүгээ тэднийг орхихгүй харин үлдэж мөн тэдэнтэй хамт мөхөх нь дээр хэмээсэн нь олон байв. Мөн үлдсэн нь эхнэр хүүхдүүдээ орхиж мөн зугтав.

13 Мөнхүү улиран тохиох дор эхнэр мөн хүүхдүүдийнхээ хамт хоцорсон тэд үзэсгэлэнт охидоо леменчүүдийн өмнө очиж зогсоогоод мөн өөрсдийг нь алахгүй байхыг гуйхаар болгов.

14 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэднийг өрөвдөв, учир нь тэд эмэгтэйчүүдийнх нь гоо үзэсгэлэнд сэтгэл татагдсан бөлгөө.

15 Тиймийн тул леменчүүд тэдний амийг хэлтрүүлж, мөн тэднийг боолчлолд оруулж мөн Нифайн нутагт буцааж авчрав, тэд хаан Ноаг леменчүүдийн гарт өгч, мөн өөрсдийн хөрөнгийг, бүр тэд эзэмшсэн бүгдийнхээ тэн хагасыг, алтныхаа мөн мөнгөнийхөө хагасыг, мөн бүх үнэт зүйлсийнхээ хагасыг өгөх нөхцөл дор тэд уг нутгийг эзэмшиж болохыг тэдэнд зөвшөөрөв, мөн тийн тэд леменчүүдийн хаанд жилээс жилд алба гувчуур төлөх ёстой байв.

16 Мөн эдүгээ боолчлолд орсон тэдний дунд хааны хөвгүүдийн нэг болох нэр нь Лимхай гэгч нэгэн байв.

17 Мөн эдүгээ Лимхай эцгээ бүү устгагдаасай хэмээх хүсэлтэй байв; гэсэн хэдий ч, Лимхай эцгийнхээ алдсуудыг үл мэдэгч биш байв, тэр өөрөө шударга хүн байсных бөлгөө.

18 Мөнхүү улиран тохиох дор Гидеон хааныг мөн түүнтэй хамт буй тэднийг хайлгахаар хүмүүсийг аглаг буйд тийш нууцаар илгээв. Мөнхүү улиран тохиох дор тэд аглаг буйдад хүмүүстэй, хаан мөн санваартнуудаас бусад бүгдтэй нь уулзав.

19 Эдүгээ тэд Нифайн нутагт эргэж очно, мөн хэрэв тэдний эхнэр мөн хүүхдүүд нь мөн түүнчлэн тэдэнтэй үлдсэн тэд алагдсан бол тэд өшөөгөө авахаар эрэлхийлнэ, мөн түүнчлэн тэдэнтэй хамт мөхөх болно хэмээн тэд зүрх сэтгэлдээ андгайлсан байв.

20 Мөн хаан тэднийг буцах ёсгүй хэмээн тэдэнд зарлиг болов; мөн тэд хаанд уурлаж, мөн түүнийг зовох болгов, бүр галд шатаагдах үхлийг хүртэл буюу.

21 Мөн тэд санваартнуудыг ч түүнчлэн барьж мөн тэднийг үхэлд хүргэхээр завдаж байв, мөн тэд тэднээс зугтан одов.

Now there were many that would not leave them, but had rather stay and perish with them. And the rest left their wives and their children and fled.

And it came to pass that those who tarried with their wives and their children caused that their fair daughters should stand forth and plead with the Lamanites that they would not slay them.

And it came to pass that the Lamanites had compassion on them, for they were charmed with the beauty of their women.

Therefore the Lamanites did spare their lives, and took them captives and carried them back to the land of Nephi, and granted unto them that they might possess the land, under the conditions that they would deliver up king Noah into the hands of the Lamanites, and deliver up their property, even one half of all they possessed, one half of their gold, and their silver, and all their precious things, and thus they should pay tribute to the king of the Lamanites from year to year.

And now there was one of the sons of the king among those that were taken captive, whose name was Limhi.

And now Limhi was desirous that his father should not be destroyed; nevertheless, Limhi was not ignorant of the iniquities of his father, he himself being a just man.

And it came to pass that Gideon sent men into the wilderness secretly, to search for the king and those that were with him. And it came to pass that they met the people in the wilderness, all save the king and his priests.

Now they had sworn in their hearts that they would return to the land of Nephi, and if their wives and their children were slain, and also those that had tarried with them, that they would seek revenge, and also perish with them.

And the king commanded them that they should not return; and they were angry with the king, and caused that he should suffer, even unto death by fire.

And they were about to take the priests also and put them to death, and they fled before them.

- 22 Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайн нутаг тийш буцахаар зэхэж, мөн тэд Гидеоны эрчүүдтэй уулзав. Мөн Гидеоны эрчүүд тэдэнд, тэдний эхнэр хүүхдүүдэд тохиолдсон бүгдийг; мөн тэд леменчүүдэд өөрсдийн бүх эзэмшлийн тэн хагасыг алба гувчуур болгон төлж байвал уг нутгийг эзэмшиж болно хэмээн леменчүүд тэдэнд зөвшөөрснийг ярьсан буюу.
- 23 Мөн уг хүмүүс Гидеоны эрчүүдэд тэд хааныг алснаа, мөн түүний санваартнууд тэднээс аглаг буйдын илүү алслагдсан хэсэг уруу зугтсаныг хэлэв.
- 24 Мөнхүү улиран тохиох дор тэд уг ёслолыг төгсгөсний дараа тэд Нифайн нутагт баясан эргэж ирэв, тэдний эхнэр мөн хүүхдүүд алагдсангүйн учир бөлгөө; мөн тэд хааныг яаснаа Гидеонд хэлэв.
- 25 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн хаан өөрийнх нь хүмүүс тэднийг алахгүй хэмээн тэдэнд ам өгөв.
- 26 Мөн түүнчлэн Лимхай, хааны хүү байсан учир, хаант улсыг удирдахаар хүмүүсээр тохоогдсон учир, леменчүүдийн хаанд өөрийнх нь хүмүүс түүнд алба, бүр бүх эзэмшлийнхээ тэн хагасыг төлнө хэмээн ам өгөв.
- 27 Мөнхүү улиран тохиох дор Лимхай хаант улсыг байгуулж мөн өөрийн хүмүүсийн дунд энх амгаланг тогтоож эхлэв.
- 28 Мөн леменчүүдийн хаан тэрээр Лимхайн хүмүүсийг нутагт нь байлгаж, тэднийг аглаг буйд тийш одуулахгүйн тулд нутгийн эргэн тойронд харуулууд гаргав; мөн тэрээр харуулуудаа нифайчуудаас хүлээн авсан алба гувчуураар тэтгэж байв.
- 29 Мөн эдүгээ леменчүүд тэднийг гоочилсонгүй бас устгахыг эрэлхийлсэн нь үгүй тул хаан Лимхай хаант улсдаа хоёр жилийн турш үргэлжийн энх амгаланг эдлэв.

And it came to pass that they were about to return to the land of Nephi, and they met the men of Gideon. And the men of Gideon told them of all that had happened to their wives and their children; and that the Lamanites had granted unto them that they might possess the land by paying a tribute to the Lamanites of one half of all they possessed.

And the people told the men of Gideon that they had slain the king, and his priests had fled from them farther into the wilderness.

And it came to pass that after they had ended the ceremony, that they returned to the land of Nephi, rejoicing, because their wives and their children were not slain; and they told Gideon what they had done to the king.

And it came to pass that the king of the Lamanites made an oath unto them, that his people should not slay them.

And also Limhi, being the son of the king, having the kingdom conferred upon him by the people, made oath unto the king of the Lamanites that his people should pay tribute unto him, even one half of all they possessed.

And it came to pass that Limhi began to establish the kingdom and to establish peace among his people.

And the king of the Lamanites set guards round about the land, that he might keep the people of Limhi in the land, that they might not depart into the wilderness; and he did support his guards out of the tribute which he did receive from the Nephites.

And now king Limhi did have continual peace in his kingdom for the space of two years, that the Lamanites did not molest them nor seek to destroy them.

## Мозая 20

- 1 Эдүгээ Шимлонд леменчүүдийн охид хамтдаа дуулж, бүжиглэж, мөн цэнгэцгээхээр цуглардаг нэгэн газар байлаа.
- 2 Мөнхүү улиран тохиох дор нэгэн өдөр тэднээс цөөн хэд нь дуулж, бүжиглэхээр цугларцгаасан бөлгөө.
- 3 Мөн эдүгээ хаан Ноагийн санваартнууд, Нифай хотод эргэж очихоос ичиж, тийм ээ, мөн түүнчлэн хүмүүс тэднийг алах болов уу гэхээс айж, тиймийн тул тэд эхнэр, хүүхдүүддээ буцаж зүрхэлсэнгүй.
- 4 Мөн аглаг буйдад үлдсэн учир, мөн леменчүүдийн охидыг олж мэдсэний учир, тэд нуугдаж хэвтэн мөн тэднийг ажиглав;
- 5 Мөн цөөн хэд нь бүжиглэхээр цугларсан үед, тэд нуугдсан газруудаасаа гарч ирээд мөн тэднийг барьж, мөн тэднийг аглаг буйд тийш авч одов; тийм ээ, леменчүүдийн охидоос хорин дөрвийг нь тэд аглаг буйд тийш авч одсон буюу.
- 6 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэдний охид алга болсныг олж мэдээд, тэд Лимхайн хүмүүст уурлав, учир нь энэ нь Лимхайн хүмүүс байсан гэж тэд боджээ.
- 7 Тиймийн тул тэд их цэргээ илгээв; тийм ээ, бүр хаан өөрөө хүмүүсийнхээ өмнө явав; мөн тэд Лимхайн хүмүүсийг устгахаар Нифайн нутаг өөд одов.
- 8 Мөн эдүгээ Лимхай тэднийг цамхгаас олж хараад, бүр дайны бүрэн бэлтгэлтэй байгааг тэр олж мэдэв; тиймийн тул тэр хүмүүсээ цуглуулж, мөн талбайд мөн ойд хэвтэн тэднийг хүлээв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг өгсөж ирэх үед, Лимхайн хүмүүс хүлээж байсан газраасаа гарч тэдний зүг дайран, мөн тэднийг алж эхлэв.
- 10 Мөнхүү улиран тохиох дор тулалдаан үлэмж ширүүн болов, учир нь тэд идшээ харамласан арслангууд лугаа адил тулалдсан бөлгөө.

## Mosiah 20

Now there was a place in Shemlon where the daughters of the Lamanites did gather themselves together to sing, and to dance, and to make themselves merry.

And it came to pass that there was one day a small number of them gathered together to sing and to dance.

And now the priests of king Noah, being ashamed to return to the city of Nephi, yea, and also fearing that the people would slay them, therefore they durst not return to their wives and their children.

And having tarried in the wilderness, and having discovered the daughters of the Lamanites, they laid and watched them;

And when there were but few of them gathered together to dance, they came forth out of their secret places and took them and carried them into the wilderness; yea, twenty and four of the daughters of the Lamanites they carried into the wilderness.

And it came to pass that when the Lamanites found that their daughters had been missing, they were angry with the people of Limhi, for they thought it was the people of Limhi.

Therefore they sent their armies forth; yea, even the king himself went before his people; and they went up to the land of Nephi to destroy the people of Limhi.

And now Limhi had discovered them from the tower, even all their preparations for war did he discover; therefore he gathered his people together, and laid wait for them in the fields and in the forests.

And it came to pass that when the Lamanites had come up, that the people of Limhi began to fall upon them from their waiting places, and began to slay them.

And it came to pass that the battle became exceedingly sore, for they fought like lions for their prey.

- 11 Мөнхүү улиран тохиох дор Лимхайн хүмүүс леменчүүдийг өмнөө туун ухрааж эхлэв; гэсэн хэдий ч тэд леменчүүдийн хагаст нь хүрэхгүй цөөн байв. Гэвч тэд амьдралынхаа төлөө мөн эхнэр хүүхдүүдийнхээ төлөө тулалдсан ажээ; тиймийн тул тэд улайрч мөн луунууд лугаа адил тулалдацгаав.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн хааныг үхэгсдийн дунд олов; гэвч тэр үхээгүй, шархдаж мөн газар орхигдсон байв, түүний хүмүүсийн зугталт тийм хурдан байсан ажгуу.
- 13 Мөн тэд түүнийг барьж мөн шархыг нь боогоод, мөн Лимхайн өмнө түүнийг авчирч, мөн хэлэв: Болгоогтун, леменчүүдийн хаан энд байна; тэрээр шарх олсон тул үхэгсдийн дунд унасан байв, мөн тэд түүнийг орхин оджээ; мөн болгоогтун, бид түүнийг таны өмнө авчирлаа; мөн эдүгээ түүнийг хөнөөцгөө хэмээв.
- 14 Гэвч Лимхай тэдэнд хэлэв: Та нар түүнийг хөнөөхгүй, харин би түүнийг харж болохын тулд түүнийг нааш авчрагтун. Мөн тэд түүнийг авчрав. Мөн Лимхай түүнд хэлэв: Миний хүмүүсийн эсрэг дайтахаар ирэх ямар шалтгаан танд байдаг билээ? Болгоогтун, миний хүмүүс миний танд ам өгснийг зөрчөөгүй билээ; тиймийн тул, та нар яагаад миний хүмүүст амласнаа зөрчих болов
- 15 Мөн эдүгээ хаан хэлэв: Би амлалтаа зөрчсөн, учир нь танай хүмүүс миний хүмүүсийн охидыг барьж одсон буюу; тиймийн тул, би уурандаа өөрийн хүмүүсийг танай хүмүүсийн эсрэг дайтахаар ирэх болгосон билээ.
- 16 Мөн эдүгээ Лимхай энэ явдлын талаар юу ч сонсоогүй байв; тиймийн тул тэр хэлэв: Би өөрийн хүмүүсийн дунд эрье, мөн ийм зүйлийг үйлдсэн хэн боловч мөхөх болно. Тиймийн тул тэрээр хүмүүсийнхээ дунд нэгжлэг хийлгэв.
- 17 Эдүгээ Гидеон эдгээр зүйлийг сонсоод, тэрээр хааны ахмад байсан тул тэрээр дөхөж очин мөн хаанд: Би танаас хүлцэхийг гуйя, мөн энэ хүмүүсийг бүү нэгж, мөн энэ зүйлийг тэдэн дээр бүү тохооч хэмээв.
- 18 Учир нь та энэ хүмүүсийг устгахаар эрэлхийлсэн эцгийнхээ санваартнуудыг санахгүй байна гэж үү? Мөн тэд аглаг буйдад байгаа бус уу? Мөн леменчүүдийн охидыг хулгайлсан нь тэд бус уу

And it came to pass that the people of Limhi began to drive the Lamanites before them; yet they were not half so numerous as the Lamanites. But they fought for their lives, and for their wives, and for their children; therefore they exerted themselves and like dragons did they fight.

And it came to pass that they found the king of the Lamanites among the number of their dead; yet he was not dead, having been wounded and left upon the ground, so speedy was the flight of his people.

And they took him and bound up his wounds, and brought him before Limhi, and said: Behold, here is the king of the Lamanites; he having received a wound has fallen among their dead, and they have left him; and behold, we have brought him before you; and now let us slay him.

But Limhi said unto them: Ye shall not slay him, but bring him hither that I may see him. And they brought him. And Limhi said unto him: What cause have ye to come up to war against my people? Behold, my people have not broken the oath that I made unto you; therefore, why should ye break the oath which ye made unto my people?

And now the king said: I have broken the oath because thy people did carry away the daughters of my people; therefore, in my anger I did cause my people to come up to war against thy people.

And now Limhi had heard nothing concerning this matter; therefore he said: I will search among my people and whosoever has done this thing shall perish. Therefore he caused a search to be made among his people.

Now when Gideon had heard these things, he being the king's captain, he went forth and said unto the king: I pray thee forbear, and do not search this people, and lay not this thing to their charge.

For do ye not remember the priests of thy father, whom this people sought to destroy? And are they not in the wilderness? And are not they the ones who have stolen the daughters of the Lamanites?

19 Мөн эдүгээ, болгоогтун, мөн эдгээр зүйлийг хаанд хэлэгтүн, тэднийг бидний тухайд тайвшруулж болохын тулд тэрээр өөрийн хүмүүст хэлж болохын тулд буюу; учир нь болгоогтун тэд аль хэдийн бидний эсрэг ирэхээр бэлтгэж байна; мөн болгоогтун түүнчлэн бид цөөн билээ.

20 Мөн болгоогтун, тэд олон тооны дайчидтайгаа ирэх болно; мөн хаан тэднийг бидний тухайд тайвшруулахаас бусдаар бол бид мөхөх ёстой боллоо.

21 Учир нь бидний эсрэг түүний бошиглосон—мөн энэ бүгд бид Их Эзэний үгсийг анхааран сонсохгүй мөн алдсуудаасаа салахгүй байгаагийн учир, мөнөөх Абинадайн үгс биелэгдсэн бус уу

22 Мөн эдүгээ хааныг тайвшруулцгаая, мөн бид түүнд өгсөн амлалтаа биелүүлье; учир нь амиа алдсанаас боолчлолд байх нь илүү дээр бөлгөө; тиймийн тул, ийм их цус урсгахаа зогсооцгооё.

23 Мөн эдүгээ эцгийнхээ мөн аглаг буйдад зугтсан санваартнуудынхаа талаар бүх зүйлийг Лимхай хаанд хэлж, мөн охидыг нь авч одсон хэмээн тэднийг буруутгав.

24 Мөнхүү улиран тохиох дор хаан түүний хүмүүсийн тухайд тайвшрав; мөн тэрээр тэдэнд: Бүгдээрээ зэвсэггүйгээр миний хүмүүстэй уулзахаар явцгаая; мөн би та нарт миний хүмүүс танай хүмүүсийг алахгүй хэмээн ам өгч тангараглая гэв.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд хааныг дагаж, мөн зэвсэггүйгээр леменчүүдтэй уулзахаар явлаа. Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдтэй уулзав; мөн леменчүүдийн хаан тэдний өмнө өөрөө бөхийж, мөн Лимхайн хүмүүсийн өмнөөс гуйв.

26 Мөн леменчүүд Лимхайн хүмүүсийг зэвсэггүй байгааг хараад тэднийг өрөвдөж мөн тэдний тухайд тайвшрав, мөн хаантайгаа хамт нутгийнхаа зүг амар амгалан буцацгаав.

And now, behold, and tell the king of these things, that he may tell his people that they may be pacified towards us; for behold they are already preparing to come against us; and behold also there are but few of us.

And behold, they come with their numerous hosts; and except the king doth pacify them towards us we must perish.

For are not the words of Abinadi fulfilled, which he prophesied against us—and all this because we would not hearken unto the words of the Lord, and turn from our iniquities?

And now let us pacify the king, and we fulfil the oath which we have made unto him; for it is better that we should be in bondage than that we should lose our lives; therefore, let us put a stop to the shedding of so much blood.

And now Limhi told the king all the things concerning his father, and the priests that had fled into the wilderness, and attributed the carrying away of their daughters to them.

And it came to pass that the king was pacified towards his people; and he said unto them: Let us go forth to meet my people, without arms; and I swear unto you with an oath that my people shall not slay thy people.

And it came to pass that they followed the king, and went forth without arms to meet the Lamanites. And it came to pass that they did meet the Lamanites; and the king of the Lamanites did bow himself down before them, and did plead in behalf of the people of Limhi.

And when the Lamanites saw the people of Limhi, that they were without arms, they had compassion on them and were pacified towards them, and returned with their king in peace to their own land.

## Мозая 21

- 1 Мөнхүү улиран тохиох дор Лимхай мөн түүний хүмүүс Нифайн хотод эргэж ирээд, мөн нутагтаа дахин амар амгалан амьдарч эхлэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор олон хоногийн дараа леменчүүд нифайчуудын эсрэг уурандаа өдөөгдөж эхлээд мөн тэд эргэн тойрны нутгийн хил орчмоор дахин ирэх болов.
- 3 Эдүгээ тэднийг хөнөөж тэд зүрхэлсэнгүй, Лимхайд өгсөн тэдний хааны амлалтын учир бөлгөө; гэвч тэд хацар дээр нь тэднийг алгадаж, мөн тэдний дээр эрх дархаа үзүүлэв; мөн тэдний нуруунд хүнд ачаануудыг тавьж мөн тэднийг хэлгүй илжиг лугаа адил тууж эхлэв—
- 4 Тийм ээ, энэ бүгд Их Эзэний үг биелэгдэж болохын тулд хийгдсэн ажгуу.
- 5 Мөн эдүгээ нифайчуудын зүдгүүрүүд агуу байж, мөн тэдний гараас тэд өөрсдийгөө чөлөөлж чадах зам үгүй байв, учир нь леменчүүд тэдний тал бүрээс бүсэлсэн ажээ.
- 6 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс өөрсдийн зүдгүүрүүдийн учир хаанд хандан бувтналдаж эхлэв; мөн тэдний эсрэг тулалдахаар явах хүсэл тэдэнд байх болов. Мөн тэд өөрсдийн гомдоллох үгсээрээ хааныг ихэд зовоож байв; тиймийн тул тэрээр тэд хүслийнхээ дагуу үйлдэхийг тэдэнд зөвшөөрөв.
- 7 Мөн тэд дахин өөрсдөө цугларцгааж, мөн хуяг дуулгаа өмсөж, мөн леменчүүдийн эсрэг тэднийг нутгаасаа хөөн гаргахаар явцгаалаа.
- 8 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тэднийг дийлж, мөн тэднийг ухраан, мөн тэдний олныг нь хөнөөв.
- 9 Мөн эдүгээ Лимхайн хүмүүсийн дунд агуу гашуудал мөн гаслан байв, бэлэвсэн эхнэр нөхрийнхөө төлөө гашуудан, хүү болон охин нь эцгийнхээ төлөө, мөн ах дүүс ах дүүсийнхээ төлөө гашуудаж байв.
- 10 Эдүгээ уг нутагт тун олон бэлэвсэн эхнэр байв, мөн тэд өдрөөс өдөрт ихээр орь дуу тавьж байв, учир нь леменчүүдээс айх их айдас тэдний дээр ирсэн бөлгөө.

## Mosiah 21

And it came to pass that Limhi and his people returned to the city of Nephi, and began to dwell in the land again in peace.

And it came to pass that after many days the Lamanites began again to be stirred up in anger against the Nephites, and they began to come into the borders of the land round about.

Now they durst not slay them, because of the oath which their king had made unto Limhi; but they would smite them on their cheeks, and exercise authority over them; and began to put heavy burdens upon their backs, and drive them as they would a dumb ass—

Yea, all this was done that the word of the Lord might be fulfilled.

And now the afflictions of the Nephites were great, and there was no way that they could deliver themselves out of their hands, for the Lamanites had surrounded them on every side.

And it came to pass that the people began to murmur with the king because of their afflictions; and they began to be desirous to go against them to battle. And they did afflict the king sorely with their complaints; therefore he granted unto them that they should do according to their desires.

And they gathered themselves together again, and put on their armor, and went forth against the Lamanites to drive them out of their land.

And it came to pass that the Lamanites did beat them, and drove them back, and slew many of them.

And now there was a great mourning and lamentation among the people of Limhi, the widow mourning for her husband, the son and the daughter mourning for their father, and the brothers for their brethren.

Now there were a great many widows in the land, and they did cry mightily from day to day, for a great fear of the Lamanites had come upon them.

11 Мөнхүү улиран тохиох дор тэдний үргэлжийн уйлаан Лимхайн хүмүүсийн үлдсэнийг леменчүүдийн эсрэг уурлуулахад өдөөн хатгав; мөн тэд дахин тулалдахаар явав, гэвч тэд дахин ухраагдаж, их хохирол хүлээв.

12 Тийм ээ, тэд бүр гурав дахь удаагаа дахин явж, мөн урьдын адил хохирол амсав; мөн алагдаагүй тэд Нифайн хотод дахин эргэж ирэв.

13 Мөн тэд өөрсдийгөө боолчлолын буулганд харьяалуулан, өөрсдийгөө цохигдохыг, мөн нааш цааш туугдахыг, мөн дайснуудынхаа хүслийн дагуу хүнд ачаа үүрэхийг хүлцэн, тэд өөрсдийгөө бүр тоос шоооотой адилтган даруусгав.

14 Мөн тэд өөрсдийгөө бүр төлөв байдлын гүнд хүргэн даруусгав; мөн тэд Бурханаас хүчтэйгээр гуйв; тийм ээ, бүр бүх өдрийн турш тэрбээр өөрсдийг нь зүдгүүрүүдээс чөлөөлөөсэй хэмээн Бурхандаа залбиран гуйсан бөлгөө.

15 Мөн эдүгээ Их Эзэн алдсуудых нь учир тэдний гуйлтыг сонсохдоо удаан байв; гэсэн хэдий ч Их Эзэн тэдний гуйлтуудыг сонсож, мөн тэдний ачааг хөнгөлж эхлэхийн тулд леменчүүдийн зүрх сэтгэлийг уярааж эхлэв; гэвч Их Эзэн тэднийг боолчлоос чөлөөлөх нь зүйд нийцнэ хэмээсэнгүй болой.

16 Мөнхүү улиран тохиох дор тэд нутагтаа бага багаар дэгжиж эхлэв, мөн тэд өлсгөлөнгөөр зовохгүйн тулд, илүү ихээр үр тариаг, мөн бог мал, мөн бод малыг өсгөж эхлэв.

17 Эдүгээ эмэгтэйчүүдийн тоо нь маш их, эрчүүдээс олон байв; тиймийн тул хаан Лимхай эр хүн болгон бэлэвсэн эхнэрүүд мөн тэдний хүүхдүүдийг, тэднийг өлсгөлөнгөөр үхүүлэхгүй байж болохын тулд тэтгэхийг зарлиг болгов; мөн тэдний үрэгдэгсдийн олны учир тэд үүнийг хийсэн ажээ.

18 Эдүгээ Лимхайн хүмүүс аль болох хэсэг хэсгээрээ хамтдаа байж, мөн тариа будаагаа мөн мал сүргээ хамгаалав;

19 Мөн хаан өөрөө харуулуудтайгаа бус аваас хотын хэрэмнээс гадагш үл гарна, тэрээр ямар нэгэн байдлаар леменчүүдийн гарт орох бий хэмээн айсны учир бөлгөө.

And it came to pass that their continual cries did stir up the remainder of the people of Limhi to anger against the Lamanites; and they went again to battle, but they were driven back again, suffering much loss.

Yea, they went again even the third time, and suffered in the like manner; and those that were not slain returned again to the city of Nephi.

And they did humble themselves even to the dust, subjecting themselves to the yoke of bondage, submitting themselves to be smitten, and to be driven to and fro, and burdened, according to the desires of their enemies.

And they did humble themselves even in the depths of humility; and they did cry mightily to God; yea, even all the day long did they cry unto their God that he would deliver them out of their afflictions.

And now the Lord was slow to hear their cry because of their iniquities; nevertheless the Lord did hear their cries, and began to soften the hearts of the Lamanites that they began to ease their burdens; yet the Lord did not see fit to deliver them out of bondage.

And it came to pass that they began to prosper by degrees in the land, and began to raise grain more abundantly, and flocks, and herds, that they did not suffer with hunger.

Now there was a great number of women, more than there was of men; therefore king Limhi commanded that every man should impart to the support of the widows and their children, that they might not perish with hunger; and this they did because of the greatness of their number that had been slain.

Now the people of Limhi kept together in a body as much as it was possible, and secured their grain and their flocks;

And the king himself did not trust his person without the walls of the city, unless he took his guards with him, fearing that he might by some means fall into the hands of the Lamanites.

20 Мөн тэрээр леменчүүдийн охидыг хулгайлж, мөн өөрсдийн дээр тийм агуу устгалыг ирүүлсэн, аглаг буйдад зугтсан мөнөөх санваартнуудыг барьж болохын тулд нутгийнхаа эргэн тойрныг өөрийн хүмүүсээр тэр тандуулав.

21 Учир нь тэд шийтгэж болохын тулд тэднийг баривчлах хүсэлтэй байв; учир нь Нифайн нутагт шөнөөр тэд ирж, мөн тэдний ургац бас үнэт зүйлээс нь олныг авч одсон ажээ; тиймийн тул тэд нуугдаж хэвтээд тэднийг хүлээв.

22 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд болон Лимхайн хүмүүсийн дунд, бүр Аммон болон түүний ах дүүсийг уг нутагт ирсэн тэр цагийг хүртэл дахин зөрчил гарсангүй.

23 Мөн хаан харуултайгаа хамт хотын хаалганы гадна байхдаа Аммон болон түүний ах дүүсийг олж харжээ; мөн тэднийг Ноагийн санваартнууд хэмээн бодож, тиймийн тул тэрээр тэднийг баривчлуульж, мөн хүлүүлж, мөн шоронд хориулсан ажгуу. Мөн хэрэв тэд Ноагийн санваартнууд байсан аваас тэр тэднийг үхэлд хүргүүлэх байсан буйза.

24 Гэвч тэрбээр тэднийг биш гэдгийг, харин тэд Зарахемлагийн нутгаас ирсэн өөрийнх нь ах дүүс болохыг олж мэдээд, тэр үлэмж агуу баяраар дүүрэв.

25 Эдүгээ хаан Лимхай Аммоныг ирэхээс өмнө цөөн тооны эрчүүдийг Зарахемлагийн нутгийг хайлгахар илгээсэн байв; гэвч тэд үүнийг олж чадсангүй, мөн тэд аглаг буйдад төөрсөн бөлгөө.

26 Гэсэн хэдий ч, тэд хүмүүс суурьшсан байсан тэр нутгийг олжээ; тийм ээ, өгөр ясаар хучигдсан тэр нутгийг; тийм ээ, хүмүүс суурьшсан байсан мөн устгагдсан тэрхүү нутгийг буюу; мөн тэд, энэ нь Зарахемлагийн нутаг хэмээн бодож, Нифайн нутагт эргэж ирэн, Аммоныг ирэхээс олон бус өдрийн өмнө нутгийн хилд хүрч ирсэн бөлгөө.

27 Мөн тэд өөрсөдтэйгөө нэгэн цэдэг авчирчээ, бүр ясыг нь олсон тэдгээр хүмүүсийн цэдгийг тэд олсон байв; мөн энэ нь хүдрийн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн байв.

28 Мөн эдүгээ Аммоны амнаас хаан Мозаяд Бурханаас өгөгдсөн ийм сийлбэрүүдийг хөрвүүлж чадах бэлэг буйг мэдээд Лимхай дахин баяслаар дүүрэв; тийм ээ, мөн түүнчлэн Аммон ч баясав.

And he caused that his people should watch the land round about, that by some means they might take those priests that fled into the wilderness, who had stolen the daughters of the Lamanites, and that had caused such a great destruction to come upon them.

For they were desirous to take them that they might punish them; for they had come into the land of Nephi by night, and carried off their grain and many of their precious things; therefore they laid wait for them.

And it came to pass that there was no more disturbance between the Lamanites and the people of Limhi, even until the time that Ammon and his brethren came into the land.

And the king having been without the gates of the city with his guard, discovered Ammon and his brethren; and supposing them to be priests of Noah therefore he caused that they should be taken, and bound, and cast into prison. And had they been the priests of Noah he would have caused that they should be put to death.

But when he found that they were not, but that they were his brethren, and had come from the land of Zarahemla, he was filled with exceedingly great joy.

Now king Limhi had sent, previous to the coming of Ammon, a small number of men to search for the land of Zarahemla; but they could not find it, and they were lost in the wilderness.

Nevertheless, they did find a land which had been peopled; yea, a land which was covered with dry bones; yea, a land which had been peopled and which had been destroyed; and they, having supposed it to be the land of Zarahemla, returned to the land of Nephi, having arrived in the borders of the land not many days before the coming of Ammon.

And they brought a record with them, even a record of the people whose bones they had found; and it was engraven on plates of ore.

And now Limhi was again filled with joy on learning from the mouth of Ammon that king Mosiah had a gift from God, whereby he could interpret such engravings; yea, and Ammon also did rejoice.



29 Гэвч тэдний ах дүүсээс ийм олон нь алагдсаны учир Аммон болон түүний ах дүүс харамслаар дүүрэн байлаа;

30 Мөн түүнчлэн хаан Ноа болон түүний санваартнууд хүмүүсийг Бурханы эсрэг ийм олон нүгэл мөн алдсуудыг үйлдэхэд хүргэсэн учир; мөн тэд түүнчлэн Абинадайн үхлийн төлөө гашуудав; мөн түүнчлэн Бурханы хүч болон чадлаар, мөн Абинадайгаар яригдсан үгсэд итгэсэн итгэлээр Бурханы сүмийг байгуулсан Алма мөн түүнтэй хамт одсон хүмүүс дайжин одсоны төлөө болой.

31 Тийм ээ, тэднийг дайжсаны төлөө тэд гашуудаж байлаа, учир нь тэд хааш зугтсаныг тэд мэдэхгүй байв. Эдүгээ тэд баяртайгаар тэдэнтэй нэгдэх байсан сан, учир нь тэд өөрсдөө түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагахаар Бурхантай гэрээнд орсон болой.

32 Мөн эдүгээ Аммоныг ирснээс хойш түүнчлэн хаан Лимхай, мөн түүнчлэн түүний хүмүүсийн олон нь түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагахаар Бурхантай гэрээнд орсон байв.

33 Мөнхүү улиран тохиох дор хаан Лимхай хийгээд түүний хүмүүсийн олон нь баптисм хүртэх хүсэлтэй байв; гэвч уг нутагт Бурханаас эрх мэдэлтэй нь нэг ч байсангүй. Мөн Аммон өөрийгөө зохист бус үйлчлэгч хэмээн бодож, энэ зүйлийг хийхээс татгалзав.

34 Тиймийн тул, тэд Их Эзэний Сүнсийг хүлээж байсны учир тэр цагт өөрсдийгөө сүм болгон зохион байгуулсангүй. Эдүгээ тэд бүр аглаг буйдад зугтсан Алма болон түүний ах дүүс лугаа адил болох хүсэлтэй байв.

35 Бүх зүрх сэтгэлээрээ тэд Бурханд үйлчлэхэд бэлнийхээ баталгаа хийгээд гэрч болгон тэд баптисм хүртэх хүсэлтэй байв; гэсэн хэдий ч тэд уг цагийг хойш тавив; мөн тэдний баптисмын шастир хожим өгөгдөх болно.

36 Мөн эдүгээ Аммоны мөн түүний хүмүүсийн, мөн хаан Лимхай болон түүний хүмүүсийн бүхий л бодолхийлэл нь өөрсдийгөө леменчүүдийн гараас мөн боолчлолоос чөлөөлөхөд зориулагдсан бөлгөө.

Yet Ammon and his brethren were filled with sorrow because so many of their brethren had been slain;

And also that king Noah and his priests had caused the people to commit so many sins and iniquities against God; and they also did mourn for the death of Abinadi; and also for the departure of Alma and the people that went with him, who had formed a church of God through the strength and power of God, and faith on the words which had been spoken by Abinadi.

Yea, they did mourn for their departure, for they knew not whither they had fled. Now they would have gladly joined with them, for they themselves had entered into a covenant with God to serve him and keep his commandments.

And now since the coming of Ammon, king Limhi had also entered into a covenant with God, and also many of his people, to serve him and keep his commandments.

And it came to pass that king Limhi and many of his people were desirous to be baptized; but there was none in the land that had authority from God. And Ammon declined doing this thing, considering himself an unworthy servant.

Therefore they did not at that time form themselves into a church, waiting upon the Spirit of the Lord. Now they were desirous to become even as Alma and his brethren, who had fled into the wilderness.

They were desirous to be baptized as a witness and a testimony that they were willing to serve God with all their hearts; nevertheless they did prolong the time; and an account of their baptism shall be given hereafter.

And now all the study of Ammon and his people, and king Limhi and his people, was to deliver themselves out of the hands of the Lamanites and from bondage.

## Мозая 22

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Аммон болон хаан Лимхай тэд өөрсдийгөө хэрхэн боолчлолоос чөлөөлөх талаар хүмүүстэйгээ зөвлөлдөж эхлэв; мөн тэд бүр бүх хүмүүсийг цуглахаар болгов; мөн тэд үүнийг уг хэргийн талаар хүмүүсийн саналыг мэдэж болохын тулд үйлдэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэд эмэгтэйчүүд мөн хүүхдүүдээ, мөн бог мөн бод малаа, мөн майхнуудаа авч мөн аглаг буйд тийш одохоос өөр, өөрсдийгөө боолчлолоос чөлөөлөх ямар ч зам тэдэнд олдсонгүй; учир нь леменчүүд маш олон тоотой байсан тул, илдээр өөрсдийгөө боолчлолоос чөлөөлнө хэмээн бодож тэдэнтэй тэмцэлдэх нь Лимхайн хүмүүсийн хувьд боломжгүй байв.
- 3 Эдүгээ улиран тохиох дор Гидеон дөхөж очин хааны өмнө зогсоод, мөн түүнд хэлэв: Эдүгээ, Ай хаантан, та эдүгээг хүртэл бид өөрсдийн ах дүүс, леменчүүдтэй тэмцэлдэж байхад миний үгсийг олон удаа сонссон билээ.
- 4 Мөн эдүгээ Ай хаантан, хэрэв та намайг ашиггүй зарц хэмээн эс тооцсон, өөрөөр хэлбэл эдүгээг хүртэл миний үгсийг ямар нэгэн хэмжээгээр сонсож, мөн тэдгээр нь танд тус болсон аваас, тэрчлэн энэ үед таныг миний үгсийг анхааран сонсоосой хэмээн хүснэ би, мөн би таны зарц байж мөн энэ хүмүүсийг боолчлолоос чөлөөлөх болно.
- 5 Мөн хаан түүнд тэрээр ярьж болно хэмээн зөвшөөрөв. Мөн Гидеон түүнд ярьсан нь:
- 6 Хотын ар талд буй арын ханыг, арын гарцыг болгоогтун. Леменчүүд, өөрөөр хэлбэл леменчүүдийн харуулууд, шөнөөр согтуу байдаг; тиймийн тул тэд шөнөөр тэдгээрийг аглаг буйд тийш тууж болохын тулд бог мөн бод малаа цуглуулцгаа хэмээн энэ бүх хүмүүсийн дунд зар тараая.
- 7 Мөн би таны зарлигийн дагуу явж мөн леменчүүдэд дарсны сүүлчийн албыг төлье, мөн тэд согтох болно; мөн тэднийг согтоод мөн унтаж байх зуур тэдний байрлалын зүүн гар талын нууц гарцаар бид гарах болно.
- 8 Тийн бид эмэгтэйчүүд мөн хүүхдүүдтэйгээ, бог мөн бод малтайгаа аглаг буйд тийш дайжих болно; мөн бид Шиломын нутгийг тойрон явах болно.

## Mosiah 22

And now it came to pass that Ammon and king Limhi began to consult with the people how they should deliver themselves out of bondage; and even they did cause that all the people should gather themselves together; and this they did that they might have the voice of the people concerning the matter.

And it came to pass that they could find no way to deliver themselves out of bondage, except it were to take their women and children, and their flocks, and their herds, and their tents, and depart into the wilderness; for the Lamanites being so numerous, it was impossible for the people of Limhi to contend with them, thinking to deliver themselves out of bondage by the sword.

Now it came to pass that Gideon went forth and stood before the king, and said unto him: Now O king, thou hast hitherto hearkened unto my words many times when we have been contending with our brethren, the Lamanites.

And now O king, if thou hast not found me to be an unprofitable servant, or if thou hast hitherto listened to my words in any degree, and they have been of service to thee, even so I desire that thou wouldst listen to my words at this time, and I will be thy servant and deliver this people out of bondage.

And the king granted unto him that he might speak. And Gideon said unto him:

Behold the back pass, through the back wall, on the back side of the city. The Lamanites, or the guards of the Lamanites, by night are drunken; therefore let us send a proclamation among all this people that they gather together their flocks and herds, that they may drive them into the wilderness by night.

And I will go according to thy command and pay the last tribute of wine to the Lamanites, and they will be drunken; and we will pass through the secret pass on the left of their camp when they are drunken and asleep.

Thus we will depart with our women and our children, our flocks, and our herds into the wilderness; and we will travel around the land of Shilom.

- 9 Мөнхүү улиран тохиох дор хаан Гидеоны үгсийг анхааран сонсов.
- 10 Мөн хаан Лимхай өөрийн хүмүүсийг мал сүргээ цуглуулах болгов; мөн тэр леменчүүдэд алба болгон дарс илгээв; мөн түүнчлэн тэрээр тэдэнд бэлэг болгон илүү дарс илгээв; мөн тэд хаан Лимхайн тэдэнд илгээсэн дарснаас ханатлаа уусан болой.
- 11 Мөнхүү улиран тохиох дор хаан Лимхайн хүмүүс шөнөөр бог мөн бод малтайгаа аглаг буйдад одож, мөн тэд Шилом нутгийг тойрон аглаг буйд тийш явж, мөн Аммон болон түүний ах дүүсээр удирдагдан Зарахемла нутгийн зүг чиглэв.
- 12 Мөн тэд тээж чадахын хэрээр бүх алт, мөн мөнгө, мөн үнэт зүйлүүдээ мөн түүнчлэн хүнсээ аглаг буйд тийш авч явсан байв; мөн тэд аянаа үргэлжлүүлэв.
- 13 Мөн аглаг буйдад олон өдөр байсны дараа тэд Зарахемла нутагт хүрэлцэн ирэв, мөн Мозаягийн хүмүүстэй нэгдэж, мөн түүний харъяатууд болов.
- 14 Мөнхүү улиран тохиох дор Мозая тэднийг баяртайгаар угтав; мөн түүнчлэн тэрээр тэдний цэдгүүдийг, мөн түүнчлэн Лимхайн хүмүүсийн олсон тэрхүү цэдгүүдийг хүлээж авав.
- 15 Мөн эдүгээ улиран тохиох дор леменчүүд Лимхайн хүмүүс шөнөөр уг нутгаас дайжин одсоныг олж мэдээд, тэднийг мөрдөн хөөлгөхөөр аглаг буйд тийш их цэрэг илгээв;
- 16 Мөн тэд хоёр өдөр тэднийг мөрдсөний эцэст, мөрийг нь дагаж чадахаа больж; тиймийн тул тэд аглаг буйдад төөрчээ.

And it came to pass that the king hearkened unto the words of Gideon.

And king Limhi caused that his people should gather their flocks together; and he sent the tribute of wine to the Lamanites; and he also sent more wine, as a present unto them; and they did drink freely of the wine which king Limhi did send unto them.

And it came to pass that the people of king Limhi did depart by night into the wilderness with their flocks and their herds, and they went round about the land of Shilom in the wilderness, and bent their course towards the land of Zarahemla, being led by Ammon and his brethren.

And they had taken all their gold, and silver, and their precious things, which they could carry, and also their provisions with them, into the wilderness; and they pursued their journey.

And after being many days in the wilderness they arrived in the land of Zarahemla, and joined Mosiah's people, and became his subjects.

And it came to pass that Mosiah received them with joy; and he also received their records, and also the records which had been found by the people of Limhi.

And now it came to pass when the Lamanites had found that the people of Limhi had departed out of the land by night, that they sent an army into the wilderness to pursue them;

And after they had pursued them two days, they could no longer follow their tracks; therefore they were lost in the wilderness.

*Хаан Ноагийн хүмүүсээр аглаг буйд тийш туугдсан Их Эзэний тэр хүмүүсийн мөн Алмагийн шастир оривой.*

## Мозая 23

- 1 Эдүгээ Алма, хаан Ноагийн их цэрэг тэдэн дээр ирэхийг Их Эзэнээс урьдаас сэрэмжлүүлэгдэж, мөн тэрээр өөрийн хүмүүст үүнийг мэдүүлсэн тул, тиймийн тул тэд мал сүргээ цуглуулж, мөн үр тарианаасаа аваад, мөн хаан Ноагийн их цэргээс өмнө аглаг буйд тийш дайжив.
- 2 Мөн хаан Ноагийн хүмүүс тэднийг устгахаар тэднийг гүйцэж чадахгүйн тулд Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн болой.
- 3 Мөн тэд найм хоногийн турш аглаг буйдаар зугтав.
- 4 Мөн тэд нэгэн нутагт тийм ээ, бүр маш үзэсгэлэнтэй мөн тааламжтай нутагт, цэвэр уст нутагт иржээ.
- 5 Мөн тэд майхнуудаа босгож, мөн газар боловсруулж эхлэв, мөн барилгууд барьж эхлэв; тийм ээ, тэд ажилсаг байж, мөн үлэмж шаргуу хөдөлмөрлөсөн болой.
- 6 Мөн хүмүүс Алмаг өөрсдийн хаан байгаасай хэмээн хүсч байв, учир нь тэр өөрийн хүмүүсээр хайрлагдсан бөлгөө.
- 7 Гэвч тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, бидэнд хаан байх нь зохистой бус юм; учир нь Их Эзэн ийн хэлдэг: Та нар нэгэн биеийг нөгөөгөөс илүүд үзэх ёсгүй, өөрөөр хэлбэл хэн нэг нь өөрийгөө бусдаас дээгүүрт бодох ёсгүй; тиймийн тул би та нарт хэлье, та нар хаантай байх нь зохистой бус.
- 8 Гэсэн хэдий ч, хэрэв та нар шударга эрчүүдийг хаан болгож чадах үргэлжийн боломжтой байсан бол хаантай байх нь та нарт сайн юм.
- 9 Гэвч хаан Ноагийн мөн түүний санваартнуудын алдсыг санагтун; мөн би өөрөө ч урхинд орсон байж, мөн намайг зовлонт наманчлалд хүргэсэн, Их Эзэний мэлмийд жигшүүрт болох тэр олон зүйлийг үйлдсэн билээ.

*An account of Alma and the people of the Lord, who were driven into the wilderness by the people of King Noah.*

## Mosiah 23

Now Alma, having been warned of the Lord that the armies of king Noah would come upon them, and having made it known to his people, therefore they gathered together their flocks, and took of their grain, and departed into the wilderness before the armies of king Noah.

And the Lord did strengthen them, that the people of king Noah could not overtake them to destroy them.

And they fled eight days' journey into the wilderness.

And they came to a land, yea, even a very beautiful and pleasant land, a land of pure water.

And they pitched their tents, and began to till the ground, and began to build buildings; yea, they were industrious, and did labor exceedingly.

And the people were desirous that Alma should be their king, for he was beloved by his people.

But he said unto them: Behold, it is not expedient that we should have a king; for thus saith the Lord: Ye shall not esteem one flesh above another, or one man shall not think himself above another; therefore I say unto you it is not expedient that ye should have a king.

Nevertheless, if it were possible that ye could always have just men to be your kings it would be well for you to have a king.

But remember the iniquity of king Noah and his priests; and I myself was caught in a snare, and did many things which were abominable in the sight of the Lord, which caused me sore repentance;

10 Гэсэн хэдий ч, их гарчлалын эцэст, Их Эзэн миний гуйлтуудыг сонссон, мөн миний залбирлуудад хариулсан, мөн намайг та нараас олныг нь түүний үнэн мэдлэгт авчрах өөрийн мутар дахь зэмсэг болгосон бөлгөө.

11 Гэсэн хэдий ч, үүгээр би бахархахгүй, учир нь би бол өөрөөрөө бахархахаар зохистой нь биш.

12 Мөн эдүгээ би та нарт хэлье, та нар хаан Ноад дарамтлуулж байсан, мөн түүний, мөн түүний санваартнуудын боолчлолд байсан, мөн тэднээр алдаст хүргэгдсэн; тиймийн тул та нар алдсын хүлгээр хүлэгдсэн байсан бөлгөө.

13 Мөн эдүгээ та нар Бурханы хүчээр эдгээр хүлээснээс. Тийм ээ, бүр хаан Ноагийн мөн түүний хүмүүсийн гараас, мөн түүнчлэн алдсын хүлээснээс, чөлөөлөгдсөн шиг; тэрчлэн та нар чөлөөлөгдсөн энэ эрх чөлөөндөө бат зогсож, мөн та нарын дээр хаан байх ямар ч хүнд итгэхгүй байгаасай хэмээн хүснэ би.

14 Мөн түүнчлэн түүний замуудаар замнан мөн зарлигуудыг нь дагадаг, Бурханы хүн байхаас бусдаар бол та нар өөрсдийн багш мөн тохинуулагч болгохоор хэнд ч бүү итгэ.

15 Тийн Алма өөрсдийн дунд зөрчилдөөнгүй байхын тулд хүн бүр хөршөө өөрийн адил хайрлах ёстой хэмээн өөрийн хүмүүст заав.

16 Мөн эдүгээ, Алма тэдний дээд санваартан байв, тэрээр тэдний сүмийг үндэслэгч байсны учир буюу.

17 Мөнхүү улиран тохиох дор номлох эсвэл багшлах эрх мэдлийг Бурханаас бус аваас түүгээр дамжуулан хэн ч хүлээн авдаггүй. Тиймийн тул тэр тэдний бүх санваартнуудыг мөн бүх багш нарыг нь адислан томилон; мөн тэд шударга бус аваас нэг нь ч адислан томилогдоогүй бөлгөө.

18 Тиймийн тул тэд өөрсдийн хүмүүсийг харж хандсан, мөн тэднийг зөв шударгад хамаарах зүйлүүд дээр дэмжин асарсан болой.

19 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутагт үлэмж дэгжиж эхлэв; мөн тэд уг нутгийг Хилам гэж нэрлэв.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд Хиламын нутагт өнөржин мөн үлэмж дэгжив; мөн тэд нэгэн хот барьж, мөн үүнийг Хиламын хот хэмээн нэрлэв.

Nevertheless, after much tribulation, the Lord did hear my cries, and did answer my prayers, and has made me an instrument in his hands in bringing so many of you to a knowledge of his truth.

Nevertheless, in this I do not glory, for I am unworthy to glory of myself.

And now I say unto you, ye have been oppressed by king Noah, and have been in bondage to him and his priests, and have been brought into iniquity by them; therefore ye were bound with the bands of iniquity.

And now as ye have been delivered by the power of God out of these bonds; yea, even out of the hands of king Noah and his people, and also from the bonds of iniquity, even so I desire that ye should stand fast in this liberty wherewith ye have been made free, and that ye trust no man to be a king over you.

And also trust no one to be your teacher nor your minister, except he be a man of God, walking in his ways and keeping his commandments.

Thus did Alma teach his people, that every man should love his neighbor as himself, that there should be no contention among them.

And now, Alma was their high priest, he being the founder of their church.

And it came to pass that none received authority to preach or to teach except it were by him from God. Therefore he consecrated all their priests and all their teachers; and none were consecrated except they were just men.

Therefore they did watch over their people, and did nourish them with things pertaining to righteousness.

And it came to pass that they began to prosper exceedingly in the land; and they called the land Helam.

And it came to pass that they did multiply and prosper exceedingly in the land of Helam; and they built a city, which they called the city of Helam.

21 Гэсэн хэдий ч Их Эзэн өөрийн хүмүүсийг зэмлэх нь зүйд нийцэх бөлгөө; тийм ээ, тэрээр тэдний гэвчээр мөн тэдний итгэлийг сорьдог билээ.

22 Гэсэн хэдий ч—түүнд найдлага тавих хэн боловч мөнхүү тэр нь эцсийн өдөр өргөмжлөгдөх болно. Тийм ээ, мөн энэ хүмүүсийн хувьд тийн байв.

23 Учир нь болгоогтун, тэд боолчлолд оруулагдсан байв, мөн Их Эзэн тэдний Бурхан, тийм ээ, бүр Абрахамын Исаакийн мөн Иаковын Бурханаас өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүйг би та нарт үзүүлэх болно.

24 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэднийг чөлөөлсөн, мөн өөрийн их хүчийг тэрээр тэдэнд үзүүлсэн билээ, мөн тэдний баясал агуу их байв.

25 Учир нь болгоогтун, улиран тохиох дор тэд Хиламын нутагт байхад, тийм ээ, Хиламын хотод, газар боловсруулж байх үед, болгоогтун леменчүүдийн их цэрэг нутгийн хилийн дотор орж ирэв.

26 Эдүгээ улиран тохиох дор Алмагийн ах дүүс талбайгаасаа зугтаж, мөн Хиламын хотод нэгдэн цугларцгаав; мөн тэд леменчүүд үзэгдсэний улмаас маш их айсан ажээ.

27 Гэвч Алма урагшлан мөн тэдний дунд зогсоод, мөн тэд айх ёсгүй, харин тэд Их Эзэн Бурханаа санах ёстой мөн тэрээр тэднийг чөлөөлнө хэмээн ухуулав.

28 Тиймийн тул тэд айдсаа дарж, мөн тэднийг, мөн тэдний эхнэрүүдийг, мөн тэдний хүүхдүүдийг хэлтрүүлэхийн тулд леменчүүдийн зүрхийг уяраахыг тэд Их Эзэнээс гуйж эхлэв.

29 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн леменчүүдийн зүрх сэтгэлийг уяраасан болой. Мөн Алма мөн түүний ах дүүс урагшлан мөн өөрсдийгөө тэдний гарт өгөв; мөн леменчүүд Хиламын нутгийг эзэмшилдээ авав.

30 Эдүгээ хаан Лимхайн хүмүүсийн араас мөрдсөн леменчүүдийн их цэрэг олон хоногийн турш аглаг буйдад төөрсөн аж.

31 Мөн болгоогтун, тэд хаан Ноагийн мөнөөх санваартнуудыг, Амюлон гэж тэдний нэрлэсэн тэр нутагт олжээ; мөн тэд Амюлоны нутгийг эзэмшиж эхлэн мөн газар боловсруулж эхэлсэн байв.

Nevertheless the Lord seeth fit to chasten his people; yea, he trieth their patience and their faith.

Nevertheless—whosoever putteth his trust in him the same shall be lifted up at the last day. Yea, and thus it was with this people.

For behold, I will show unto you that they were brought into bondage, and none could deliver them but the Lord their God, yea, even the God of Abraham and Isaac and of Jacob.

And it came to pass that he did deliver them, and he did show forth his mighty power unto them, and great were their rejoicings.

For behold, it came to pass that while they were in the land of Helam, yea, in the city of Helam, while tilling the land round about, behold an army of the Lamanites was in the borders of the land.

Now it came to pass that the brethren of Alma fled from their fields, and gathered themselves together in the city of Helam; and they were much frightened because of the appearance of the Lamanites.

But Alma went forth and stood among them, and exhorted them that they should not be frightened, but that they should remember the Lord their God and he would deliver them.

Therefore they hushed their fears, and began to cry unto the Lord that he would soften the hearts of the Lamanites, that they would spare them, and their wives, and their children.

And it came to pass that the Lord did soften the hearts of the Lamanites. And Alma and his brethren went forth and delivered themselves up into their hands; and the Lamanites took possession of the land of Helam.

Now the armies of the Lamanites, which had followed after the people of king Limhi, had been lost in the wilderness for many days.

And behold, they had found those priests of king Noah, in a place which they called Amulon; and they had begun to possess the land of Amulon and had begun to till the ground.

- 32 Эдүгээ тэдгээр санваартнуудын удирдагчийн нэр нь Амюлон байв.
- 33 Мөнхүү улиран тохиох дор Амюлон леменчүүдээс гуйв; мөн тэрээр түүнчлэн леменчүүдийн охид болох эхнэрүүдээ эр нөхрүүдийг нь устгахгүй байхыг ах дүүсээс нь гуйлгахаар урагш илгээв.
- 34 Мөн леменчүүд Амюлон болон түүний ах дүүсийг өрөвдөж, мөн тэднийг устгасангүй, тэдний эхнэрүүдийн учир бөлгөө.
- 35 Мөн Амюлон мөн түүний ах дүүс леменчүүдтэй нэгдэв, мөн тэд Нифайн нутгийг хайн аглаг буйдад аялж байх үедээ Алма болон түүний ах дүүсийн эзэмшиж байсан Хиламын нутгийг олж мэдэв.
- 36 Мөнхүү улиран тохиох дор хэрэв тэд Нифайн нутагт хүргэх замыг тэдэнд зааж өгвөл тэд амийг нь мөн тэдний эрх чөлөөг өгөх болно хэмээн леменчүүд Алма болон түүний ах дүүст амласан буюу.
- 37 Гэвч Алма тэдэнд Нифайн нутагт хүрэх замыг зааж өгсний дараа леменчүүд амлалтаа биелүүлсэнгүй; харин тэд Алма болон түүний ах дүүсийн дээр Хиламын нутгийн эргэн тойронд харуулууд суулгав.
- 38 Мөн тэдний бусад нь Нифайн нутгийн зүг одов; мөн тэдний нэг хэсэг нь Хиламын нутагт буцаж ирсэн аж, мөн түүнчлэн уг нутагт үлдээгдсэн харуулуудын эхнэр мөн хүүхдүүдийг өөрсөдтэйгээ авчирсан бөлгөө.
- 39 Мөн леменчүүдийн хаан Хиламын нутагт байсан өөрийн хүмүүсийн хаан бас захирагч байхыг Амюлонд зөвшөөрөв; гэсэн хэдий ч тэрээр леменчүүдийн хааны таалалд үл нийцэх ямар ч зүйлийг хийх хүч үгүй бөлгөө.

Now the name of the leader of those priests was Amulon.

And it came to pass that Amulon did plead with the Lamanites; and he also sent forth their wives, who were the daughters of the Lamanites, to plead with their brethren, that they should not destroy their husbands.

And the Lamanites had compassion on Amulon and his brethren, and did not destroy them, because of their wives.

And Amulon and his brethren did join the Lamanites, and they were traveling in the wilderness in search of the land of Nephi when they discovered the land of Helam, which was possessed by Alma and his brethren.

And it came to pass that the Lamanites promised unto Alma and his brethren, that if they would show them the way which led to the land of Nephi that they would grant unto them their lives and their liberty.

But after Alma had shown them the way that led to the land of Nephi the Lamanites would not keep their promise; but they set guards round about the land of Helam, over Alma and his brethren.

And the remainder of them went to the land of Nephi; and a part of them returned to the land of Helam, and also brought with them the wives and the children of the guards who had been left in the land.

And the king of the Lamanites had granted unto Amulon that he should be a king and a ruler over his people, who were in the land of Helam; nevertheless he should have no power to do anything contrary to the will of the king of the Lamanites.

## Мозая 24

- 1 Мөнхүү улиран тохиох дор Амюлон леменчүүдийн хааны мэлмийд тааллыг олов; тиймийн тул, леменчүүдийн хаан түүнд болон түүний ах дүүст, хүмүүсийнхээ дээр. Тийм ээ, бүр Шимлоны нутагт байсан, мөн Шиломын нутагт, мөн Амюлоны нутагт байсан тэр хүмүүсийн дээр багшаар томилогдсон байхыг зөвшөөрчээ.
- 2 Учир нь леменчүүд эдгээр бүх нутгийг эзэмшилдээ авсан байв; тиймийн тул, леменчүүдийн хаан эдгээр бүх нутгийн дээр хаадыг томилсон бөлгөө.
- 3 Мөн эдүгээ леменчүүдийн хааны нэр нь Лемен хэмээн, эцгийнхээ нэрээр нэрлэгдсэн байв; мөн тиймийн тул тэрээр хаан Лемен гэж нэрлэгдсэн ажгуу. Мөн тэр олон тооны хүмүүсийн хаан байв.
- 4 Мөн тэрээр өөрийн хүмүүсээр эзэмшигдсэн нутаг бүрд Амюлоны ах дүүсээс багш нарыг томилов; мөн тийн Нифайн хэл леменчүүдийн бүх хүмүүсийн дунд заагдаж эхлэв.
- 5 Мөн тэд нэг нь нөгөөдөө найрсаг хүмүүс байв; гэсэн хэдий ч тэд Бурханыг мэддэггүй байлаа; бас Амюлоны ах дүүс, Их Эзэн Бурханыхаа талаар юу ч, бас Мосегийн хуулийг ч тэдэнд заасангүй; Абинадайн үгсийг ч тэдэнд заасан нь үгүй бөлгөө;
- 6 Гэвч тэд өөрсдийн цэдгийг хадгалбал зохихыг мөн тэд нэг нь нөгөөдөө бичиж болохыг заав.
- 7 Мөн тийн леменчүүд баялгаар арвижиж эхлэв, мөн бие биетэйгээ худалдаа хийж мөн хүчирхэгжиж эхлэв, мөн дэлхийн ухааны хувьд зальтай мөн мэргэн, тийм ээ, маш их зальтай, ах дүүсийнхээ дунд л биш бол ёс бус муу бүхэнд мөн дээрэм тонуулд баясан хүмүүс болж эхлэв.
- 8 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүсийн дээр Амюлон эрх дархыг үзүүлэн, мөн тэднийг хавчиж эхлэн, мөн хүүхдүүдээрээ тэдний хүүхдүүдийг хавчин дарлуулж байв.

## Mosiah 24

And it came to pass that Amulon did gain favor in the eyes of the king of the Lamanites; therefore, the king of the Lamanites granted unto him and his brethren that they should be appointed teachers over his people, yea, even over the people who were in the land of Shemlon, and in the land of Shilom, and in the land of Amulon.

For the Lamanites had taken possession of all these lands; therefore, the king of the Lamanites had appointed kings over all these lands.

And now the name of the king of the Lamanites was Laman, being called after the name of his father; and therefore he was called king Laman. And he was king over a numerous people.

And he appointed teachers of the brethren of Amulon in every land which was possessed by his people; and thus the language of Nephi began to be taught among all the people of the Lamanites.

And they were a people friendly one with another; nevertheless they knew not God; neither did the brethren of Amulon teach them anything concerning the Lord their God, neither the law of Moses; nor did they teach them the words of Abinadi;

But they taught them that they should keep their record, and that they might write one to another.

And thus the Lamanites began to increase in riches, and began to trade one with another and wax great, and began to be a cunning and a wise people, as to the wisdom of the world, yea, a very cunning people, delighting in all manner of wickedness and plunder, except it were among their own brethren.

And now it came to pass that Amulon began to exercise authority over Alma and his brethren, and began to persecute him, and cause that his children should persecute their children.



- 9 Учир нь Алмаг, тэрээр хааны санваартнуудын нэг байсныг мөн тэр Абинадайн үгсэд итгэсэн нь тэр байсныг бас хааны өмнөөс хөөгдсөнийг Амюлон мэдэж байв, мөн тиймийн тул тэр түүнд хилэгнэж байлаа; учир нь тэр хаан Лемений харъяат байв, гэсэн хэдий ч тэр тэдний дээр эрх дархаа үзүүлж, мөн тэдэнд үүрэг ажил өгч, мөн тэднийг харгалзах хянагчдыг томилжээ.
- 10 Мөнхүү улиран тохиох дор тэдний зүдгүүрүүд аймшигтай их байсан тул тэд Бурханд хүчтэйгээр залбиран гуйж эхэлсэн ажээ.
- 11 Мөн тэд өөрсдийн гуйлтуудыг зогсоох ёстой хэмээн Амюлон тэдэнд зарлиг болов; мөн тэрээр Бурханыг дуудсан хэнийг боловч үхэлд хүргэхээр тэднийг харгалзах харуулуудыг тэдний дээр тавилаа.
- 12 Мөн Алма болон түүний хүмүүс Их Эзэн Бурхандаа дуу хоолойгоо өргөсөнгүй, гэвч зүрх сэтгэлээ түүнд юулж байсан болой; мөн тэрээр тэдний зүрх сэтгэл дэх бодлуудыг мэдэж байв.
- 13 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний дуу хоолой тэдний зүдгүүрт үед ирж, өгүүлсэн нь: Тэргүүнээ өргөцгөө мөн тайтгарагтун, учир нь надад хийсэн та нарын гэрээний тухай би мэднэ; мөн өөрийн хүмүүстэй гэрээ хийж мөн тэднийг боолчлолоос чөлөөлөх болно би.
- 14 Мөн та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол, бүр та нарыг боолчлолд байх үед би түүнчлэн хөнгөлнө; мөн та нар цаашид миний гэрчлэгчид болон зогсох болно, мөн та нар, Их Эзэн Бурхан би өөрийн хүмүүст тэдний зүдгүүрт үед зочилдгийг та нар гарцаагүй мэдэж болохын би үүнийг хийх болно.
- 15 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүсийн дээр тавигдаж асан ачаанууд хөнгөлөгдсөн байлаа; тийм ээ, тэд ачаагаа амархан дааж чадахын тулд Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн билээ, мөн тэд баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдсан болой.

For Amulon knew Alma, that he had been one of the king's priests, and that it was he that believed the words of Abinadi and was driven out before the king, and therefore he was wroth with him; for he was subject to king Laman, yet he exercised authority over them, and put tasks upon them, and put task-masters over them.

And it came to pass that so great were their afflictions that they began to cry mightily to God.

And Amulon commanded them that they should stop their cries; and he put guards over them to watch them, that whosoever should be found calling upon God should be put to death.

And Alma and his people did not raise their voices to the Lord their God, but did pour out their hearts to him; and he did know the thoughts of their hearts.

And it came to pass that the voice of the Lord came to them in their afflictions, saying: Lift up your heads and be of good comfort, for I know of the covenant which ye have made unto me; and I will covenant with my people and deliver them out of bondage.

And I will also ease the burdens which are put upon your shoulders, that even you cannot feel them upon your backs, even while you are in bondage; and this will I do that ye may stand as witnesses for me hereafter, and that ye may know of a surety that I, the Lord God, do visit my people in their afflictions.

And now it came to pass that the burdens which were laid upon Alma and his brethren were made light; yea, the Lord did strengthen them that they could bear up their burdens with ease, and they did submit cheerfully and with patience to all the will of the Lord.

- 16 Мөнхүү улиран тохиох дор тэдний итгэл мөн тэдний тэвчээр тийм агуу байсан учир Их Эзэний дуу хоолой тэдэнд дахин ирж, өгүүлсэн нь: Тайтгарагтун, учир нь маргааш би та нарыг боолчлолоос чөлөөлөх болно.
- 17 Мөн тэрээр Алмад: Чи энэ хүмүүсийн өмнө явах болно, мөн би чамтай хамт явж мөн энэ хүмүүсийг боолчлолоос чөлөөлөх болно гэж хэлэв.
- 18 Эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний хүмүүс шөнийн цагаар мал сүргээ, мөн түүнчлэн үр тарианаасаа, нэгтгэн цуглуулжээ; тийм ээ, бүр бүх шөнийн турш тэд мал сүргээ нэгтгэн цуглуулав.
- 19 Мөн өглөө нь Их Эзэн леменчүүдийн дээр гүн нойр ирүүлж, тийм ээ, мөн тэдний бүх хянагчид гүн нойронд автагдсан байв.
- 20 Мөн Алма болон түүний хүмүүс аглаг буйд тийш одов; мөн тэд өдөржингөө аялаад, нэгэн хөндийд майхнуудаа босгов, мөн тэд уг хөндийг Алма гэж нэрлэв, учир нь тэрээр аглаг буйдад тэдний замыг удирдсан бөлгөө.
- 21 Тийм ээ, мөн тэр тэдэнд нигүүлсэнгүй байж мөн тэдний ачаануудыг хөнгөлж, мөн тэднийг боолчлолоос чөлөөлсөн учир тэд Алмагийн хөндийд Бурханд талархлаа уудлан илэрхийлэв; учир нь тэд боолчлолд байж, мөн Их Эзэн Бурханаас нь өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй байлаа.
- 22 Мөн тэд Бурханд талархал илэрхийлж, тийм ээ, тэдний бүх эрчүүд мөн тэдний бүх эмэгтэйчүүд мөн ярьж чадах тэдний бүх хүүхдүүд Бурханаа магтахад дуу хоолойгоо өргөсөн ажээ.
- 23 Мөн эдүгээ Их Эзэн Алмад: Чи яарагтун мөн өөрийгөө бас энэ хүмүүсийг энэ нутгаас авч гар, учир нь леменчүүд сэрсэн мөн чамайг мөшгөж байна; тиймийн тул энэ нутгаас гарцгаа, мөн би леменчүүдийг энэ хөндийд зогсоох болно, тэгснээр тэд энэ хүмүүсийг мөшгөхөөр цааш явахгүй хэмээв.
- 24 Мөнхүү улиран тохиох дор тэд уг хөндийгөөс одож, мөн аглаг буйдад аянаа хөөв.
- 25 Мөн тэд аглаг буйдад арванхоёр хоног байсны дараа тэд Зарахемлагийн нутагт хүрч ирэв; мөн хаан Мозая тэднийг түүнчлэн баяр хөөртэйгөөр угтаж авчээ.

And it came to pass that so great was their faith and their patience that the voice of the Lord came unto them again, saying: Be of good comfort, for on the morrow I will deliver you out of bondage.

And he said unto Alma: Thou shalt go before this people, and I will go with thee and deliver this people out of bondage.

Now it came to pass that Alma and his people in the night-time gathered their flocks together, and also of their grain; yea, even all the night-time were they gathering their flocks together.

And in the morning the Lord caused a deep sleep to come upon the Lamanites, yea, and all their taskmasters were in a profound sleep.

And Alma and his people departed into the wilderness; and when they had traveled all day they pitched their tents in a valley, and they called the valley Alma, because he led their way in the wilderness.

Yea, and in the valley of Alma they poured out their thanks to God because he had been merciful unto them, and eased their burdens, and had delivered them out of bondage; for they were in bondage, and none could deliver them except it were the Lord their God.

And they gave thanks to God, yea, all their men and all their women and all their children that could speak lifted their voices in the praises of their God.

And now the Lord said unto Alma: Haste thee and get thou and this people out of this land, for the Lamanites have awakened and do pursue thee; therefore get thee out of this land, and I will stop the Lamanites in this valley that they come no further in pursuit of this people.

And it came to pass that they departed out of the valley, and took their journey into the wilderness.

And after they had been in the wilderness twelve days they arrived in the land of Zarahemla; and king Mosiah did also receive them with joy.

## Мозая 25

- 1 Мөн эдүгээ хаан Мозая бүх хүмүүсийг нэгдэн цугларцгаах болгов.
- 2 Эдүгээ Нифайн хүүхдүүд, өөрөөр хэлбэл Нифайн удам болох тэд, Мюликийн болон аглаг буйдад түүнтэй хамт ирсэн тэдний удам болох Зарахемлагийн хүмүүс шиг тийм олон байсангүй.
- 3 Мөн Нифайн хүмүүс мөн Зарахемлагийн хүмүүс нийлээд ч леменчүүд шиг тийм олон байсангүй; тийм ээ, тэд тооных нь хагаст ч хүрэхгүй байв.
- 4 Мөн эдүгээ Нифайн бүх хүмүүс нэгдэн чуулж, мөн түүнчлэн Зарахемлагийн бүх хүмүүс, мөн тэд хоёр хэсэгт цугларцгааж байв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Зенифийн цэдгүүдийг Мозая өөрийн хүмүүст уншиж мөн уншигдахаар болгов; тийм ээ, тэд Зарахемла нутгийг орхисон тэр цагаас тэднийг эргэж ирснийг хүртэлх Зенифийн хүмүүсийн цэдгүүдийг тэрээр уншив.
- 6 Мөн түүнчлэн тэд Зарахемлагийн нутгийг орхисон цагаас тэд дахин эргэж ирснийг хүртэлх Алма болон түүний ах дүүсийн мөн тэдний бүх зүдгүүрийн шастирыг тэрээр уншсан бөлгөө.
- 7 Мөн эдүгээ, Мозая цэдгүүдийг уншихаа төгсгөл болгосны дараа, нутагтаа үлдсэн түүний хүмүүс гайхаж мөн бахдан догдолсон ажээ.
- 8 Учир нь тэд юу бодохоо мэдсэнгүй; учир нь тэд боолчлолоос чөлөөлөгдсөн тэднийг хараад тэд үлэмж агуу баяр хөөрөөр дүүргэгдсэн байв.
- 9 Мөн түүнчлэн, тэд леменчүүдэд алагдсан ах дүүсээ дурсахдаа тэд харамслаар дүүрэн байв, мөн бүр харамслын их нулимс асгаруулсан буюу.
- 10 Мөн түүнчлэн, тэд Бурханы эн тэргүүний сайн сайхан, мөн Алма болон түүний ах дүүсийг леменчүүдийн гараас мөн боолчлолоос чөлөөлсөн түүний хүчний тухай бодохдоо, тэд дуу хоолойгоо өргөн мөн Бурханд талархал илэрхийлэв.
- 11 Мөн түүнчлэн, тэд өөрсдийнх нь ах дүүс асан леменчүүд, тэдний нүгэлт мөн бохирдсон байдлын тухай бодохдоо тэдний бодгалиудын аз жаргалын төлөө зовлон мөн тарчлалаар дүүргэгдэв.

## Mosiah 25

And now king Mosiah caused that all the people should be gathered together.

Now there were not so many of the children of Nephi, or so many of those who were descendants of Nephi, as there were of the people of Zarahemla, who was a descendant of Mulek, and those who came with him into the wilderness.

And there were not so many of the people of Nephi and of the people of Zarahemla as there were of the Lamanites; yea, they were not half so numerous.

And now all the people of Nephi were assembled together, and also all the people of Zarahemla, and they were gathered together in two bodies.

And it came to pass that Mosiah did read, and caused to be read, the records of Zeniff to his people; yea, he read the records of the people of Zeniff, from the time they left the land of Zarahemla until they returned again.

And he also read the account of Alma and his brethren, and all their afflictions, from the time they left the land of Zarahemla until the time they returned again.

And now, when Mosiah had made an end of reading the records, his people who tarried in the land were struck with wonder and amazement.

For they knew not what to think; for when they beheld those that had been delivered out of bondage they were filled with exceedingly great joy.

And again, when they thought of their brethren who had been slain by the Lamanites they were filled with sorrow, and even shed many tears of sorrow.

And again, when they thought of the immediate goodness of God, and his power in delivering Alma and his brethren out of the hands of the Lamanites and of bondage, they did raise their voices and give thanks to God.

And again, when they thought upon the Lamanites, who were their brethren, of their sinful and polluted state, they were filled with pain and anguish for the welfare of their souls.

- 12 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн охидыг эхнэр болгон авцгаасан Амюлон болон түүний ах дүүсийн хүүхдүүд эцгүүдийнхээ үйлүүдийг үл таашааж, мөн тэд эцгүүдийнхээ нэрээр цаашид дуудагдамааргүй байсан аж, тиймийн тул тэд Нифайн хүүхдүүд гэж дуудагдаж болохын тулд мөн нифайчууд гэж нэрлэгдэгсдийн дунд тоологдож болохын тулд өөрсөд дээрээ Нифайн нэрийг авчээ.
- 13 Мөн эдүгээ Зарахемлагийн бүх хүмүүс нифайчуудтай хамт тоологдож байв, мөн энэ нь уг хаант улс Нифайн удам байсан тэднээс бусад хэний ч мэдэлд үл шилжүүлэгдэж байсны учир болой.
- 14 Мөн эдүгээ улиран тохиох дор Мозая хүмүүст ярих мөн уншихаа төгсгөл болгоод, тэрээр Алмаг түүнчлэн хүмүүст ярихыг хүсэв.
- 15 Мөн тэд том хэсгүүд болон нэгдэн чуулж байх үед Алма тэдэнд ярьсан болой, мөн тэрээр хүмүүст наманчлал мөн Их Эзэнд итгэх итгэлийг номлон нэг хэсгээс нөгөөд явав.
- 16 Мөн тэрээр Лимхайн мөн түүний ах дүүсийн боолчлолоос чөлөөлөгдсөн тэдгээр бүх хүмүүст, тэднийг чөлөөлсөн нь Их Эзэн байсныг тэд санах ёстой хэмээн ухуулав.
- 17 Мөнхүү улиран тохиох дор Алма хүмүүст олон зүйлийг зааж, мөн тэдэнд ярихаа төгсгөл болгосны дараа, хаан Лимхай баптисм хүртэх хүсэлтэй байжээ; мөн түүний бүх хүмүүс түүнчлэн баптисм хүртэх хүсэлтэй байв.
- 18 Тиймийн тул, Алма урагшлан усанд орж мөн тэдэнд баптисм хүртээв; тийм ээ, тэрээр ах дүүстээ Мормоны Усанд баптисм хүртээсний адил тийм маягаар тэдэнд баптисм хүртээв; тийм ээ, мөн түүний баптисм хүртээсэн бүхэн Бурханы сүмд хамаарагдсан болой; мөн энэ нь Алмагийн үгсэд итгэсэн тэдний итгэлийн учир бөлгөө.
- 19 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая Зарахемлагийн бүх нутаг даяар сүмүүд байгуулж болохыг Алмад зөвшөөрөв; мөн сүм бүрийн дээрх санваартнууд болон багш нарыг томилох хүчийг түүнд өгөв.

And it came to pass that those who were the children of Amulon and his brethren, who had taken to wife the daughters of the Lamanites, were displeased with the conduct of their fathers, and they would no longer be called by the names of their fathers, therefore they took upon themselves the name of Nephi, that they might be called the children of Nephi and be numbered among those who were called Nephites.

And now all the people of Zarahemla were numbered with the Nephites, and this because the kingdom had been conferred upon none but those who were descendants of Nephi.

And now it came to pass that when Mosiah had made an end of speaking and reading to the people, he desired that Alma should also speak to the people.

And Alma did speak unto them, when they were assembled together in large bodies, and he went from one body to another, preaching unto the people repentance and faith on the Lord.

And he did exhort the people of Limhi and his brethren, all those that had been delivered out of bondage, that they should remember that it was the Lord that did deliver them.

And it came to pass that after Alma had taught the people many things, and had made an end of speaking to them, that king Limhi was desirous that he might be baptized; and all his people were desirous that they might be baptized also.

Therefore, Alma did go forth into the water and did baptize them; yea, he did baptize them after the manner he did his brethren in the waters of Mormon; yea, and as many as he did baptize did belong to the church of God; and this because of their belief on the words of Alma.

And it came to pass that king Mosiah granted unto Alma that he might establish churches throughout all the land of Zarahemla; and gave him power to ordain priests and teachers over every church.

- 20 Эдүгээ бүгд нэг багшаар удирдагдаж чадахааргүй тийм олон хүн байсан учир энэ нь хийгдсэн болой; бас тэд Бурханы үгийг нэг цугларалтанд бүгд анхааран сонсож чадахааргүй байв;
- 21 Тиймийн тул тэд өөрсдөө сүм хэмээн нэрлэгдэх өөр өөр хэсгүүдэд цугларцгаав, сүм болгон өөр өөрийн санваартан мөн өөр өөрийн багш нартай, мөн санваартан бүр Алмагийн амаар түүнд өгөгдсөний дагуу үгийг номлож байв.
- 22 Мөн тийн, тэнд олон сүм байсан хэдий ч тэд бүгд нэг сүм байв, тийм ээ, бүр Бурханы сүм болой; учир нь наманчлал хийгээд Бурханд итгэхээс өөр юу ч бүх сүмд номлогддоггүй байв.
- 23 Мөн эдүгээ Зарахемлагийн нутагт долоон сүм байв. Мөнхүү улиран тохиох дор өөрсдийн дээр Христийн буюу Бурханы нэрийг авах хүсэлтэй байсан хэн боловч, тэд Бурханы сүмүүдэд нэгдэв;
- 24 Мөн тэд Бурханы хүмүүс гэж нэрлэгдэв. Мөн Их Эзэн тэдний дээр Сүнсээ юүлж, мөн тэд адислагдан, уг нутагт дэгжсэн бөлгөө.

Now this was done because there were so many people that they could not all be governed by one teacher; neither could they all hear the word of God in one assembly;

Therefore they did assemble themselves together in different bodies, being called churches; every church having their priests and their teachers, and every priest preaching the word according as it was delivered to him by the mouth of Alma.

And thus, notwithstanding there being many churches they were all one church, yea, even the church of God; for there was nothing preached in all the churches except it were repentance and faith in God.

And now there were seven churches in the land of Zarahemla. And it came to pass that whosoever were desirous to take upon them the name of Christ, or of God, they did join the churches of God;

And they were called the people of God. And the Lord did pour out his Spirit upon them, and they were blessed, and prospered in the land.

## Мозая 26

- 1 Эдүгээ улиран тохиох дор хаан Бенжамины үгсийг ойлгож чадахгүй нь өсвөр үеийнхнээс олон байв, учир нь түүнийг өөрийн хүмүүст ярьж байх тэр цагт тэд бяцхан хүүхдүүд байжээ; мөн тэд эцэг өвгөдийнхөө уламжлалд итгэсэн нь үгүй.
- 2 Тэд үхэгсдийн амилуулалтын талаар яригдсан зүйлд итгэсэнгүй, бас тэд Христийн ирэлтийн талаар ч итгэсэн нь үгүй.
- 3 Мөн эдүгээ итгэлгүйнхээ учир тэд Бурханы үгийг ойлгож чадсангүй; мөн тэдний зүрх сэтгэл хатуурсан байв.
- 4 Мөн тэд баптисм хүртээгүй байв; бас сүмд нэгдсэн нь ч үгүй. Мөн тэд сүсэг бишрэлийнхээ хувьд тусгаар хүмүүс байж, бүр өөрсдийн эгэл мөн нүгэлт байдалдаа, мөн тэр чигээр үлдэв; учир нь тэд Их Эзэн Бурханаа дууддаггүй байв.
- 5 Мөн эдүгээ Мозаягийн засаглалын үед тэд Бурханы хүмүүсийн тооны хагаст нь ч хүрэхгүй байв; гэвч гишүүдийн дундах зөрчилдөөний улмаас тэд илүү олон тоотой болов.
- 6 Учир нь, улиран тохиох дор тэд бялдууч үгсээрээ сүмд байгсдаас олныг мэхэлж, мөн тэднийг олон нүгэл үйлдэхэд хүргэсэн аж; тиймийн тул сүмд байж нүгэл үйлдсэн тэд сүмээр зэмлэгдэх ёстой нь зайлшгүй болов.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэд санваартнуудын өмнө авчрагдаж, мөн багш нараар санваартнуудад хүргэгдсэн байв; мөн санваартнууд тэднийг дээд санваартан асан Алмагийн өмнө авчирсан бөлгөө.
- 8 Эдүгээ хаан Мозая сүмийн дээрх эрх мэдлийг Алмад өгчээ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор Алма тэдний талаар мэдээгүй байв; гэвч тэдний эсрэг олон гэрч байжээ; тийм ээ, хүмүүс босч мөн тэдний алдсын талаар ихийг гэрчилж байв.
- 10 Эдүгээ сүмд урьд нь ийм зүйл нэгээхэн ч тохиолдож байсангүй; тиймийн тул Алмагийн сэтгэл зовж, мөн тэр тэднийг хааны өмнө аваачигдахаар болгов.

## Mosiah 26

Now it came to pass that there were many of the rising generation that could not understand the words of king Benjamin, being little children at the time he spake unto his people; and they did not believe the tradition of their fathers.

They did not believe what had been said concerning the resurrection of the dead, neither did they believe concerning the coming of Christ.

And now because of their unbelief they could not understand the word of God; and their hearts were hardened.

And they would not be baptized; neither would they join the church. And they were a separate people as to their faith, and remained so ever after, even in their carnal and sinful state; for they would not call upon the Lord their God.

And now in the reign of Mosiah they were not half so numerous as the people of God; but because of the dissensions among the brethren they became more numerous.

For it came to pass that they did deceive many with their flattering words, who were in the church, and did cause them to commit many sins; therefore it became expedient that those who committed sin, that were in the church, should be admonished by the church.

And it came to pass that they were brought before the priests, and delivered up unto the priests by the teachers; and the priests brought them before Alma, who was the high priest.

Now king Mosiah had given Alma the authority over the church.

And it came to pass that Alma did not know concerning them; but there were many witnesses against them; yea, the people stood and testified of their iniquity in abundance.

Now there had not any such thing happened before in the church; therefore Alma was troubled in his spirit, and he caused that they should be brought before the king.

11 Мөн тэрээр хаанд хэлэв: Болгоогтун, ах дүүсээрээ буруутгагдсан тэд, таны өмнө бидний авчирсан тэднээс олон нь энд байна; тийм ээ, мөн тэд төрөл төрлийн алдсуудыг хийсэн нь баригдсан бөлгөө. Мөн тэд алдсуудаа үл наманчилна; тиймийн тул гэмт хэргүүдийнх нь дагуу та тэднийг шүүж болно хэмээн, бид тэднийг таны өмнө авчирсан билээ.

12 Гэвч хаан Мозая Алмад хэлэв: Болгоогтун, би тэднийг үл шүүнэ; тиймийн тул би тэднийг шүүхийн тулд таны гарт шилжүүлэе.

13 Мөн эдүгээ Алмагийн сэтгэл дахин зовов; мөн тэрээр явж мөн энэ хэргийн талаар юу хийх ёстойгоо Их Эзэнээс лавлав, учир нь Бурханы мэлмийд тэр бурууг хийхвий хэмээн айсан ажээ.

14 Мөнхүү улиран тохиох дор тэр бүхий л бодгалиа мөн зүрх сэтгэлээ Бурханд юүлсний дараа, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, хэлрүүн:

15 Адислагдсан болой чи, Алма, мөн Мормоны Усанд баптисм хүртсэн тэд адислагдсан болой. Зөвхөн миний үйлчлэгч Абинадайн үгсэд итгэсэн үлэмж итгэлийнхээ учир адислагдсан болой чи.

16 Мөн, чиний тэдэнд ярьсан зөвхөн тэр үгсэд итгэх үлэмж итгэлийнхээ учир адислагдсан болой тэд.

17 Мөн чи энэ хүмүүсийн дунд сүм байгуулсны учир адислагдсан болой чи; мөн тэд тогтоогдох болно, мөн тэд миний хүмүүс байх болно.

18 Тийм ээ, миний нэрийг авахад бэлэн энэ хүмүүс адислагдсан болой; учир нь миний нэрээр тэд нэрлэгдэх болно; мөн тэд минийх болой.

19 Мөн чи зөрчигчийн талаар надаас лавласан учир, адислагдсан чи.

20 Чи бол миний үйлчлэгч; мөн чамд мөнх амьдрал байх болно хэмээн би чамтай гэрээ хийе; мөн чи надад үйлчилж мөн миний нэрээр явах болно, мөн миний хонийг нэгтгэн цуглуулах болно.

21 Мөн миний дуу хоолойг сонсох тэр нь миний хонь байх болно; мөн түүнийг та нар сүмд хүлээн авна, мөн түүнийг би түүнчлэн хүлээн авах болно.

22 Учир нь болгоогтун, энэ бол миний сүм; баптисм хүртсэн хэн боловч наманчлалд баптисм хүртэх болно. Мөн та нарын хүлээж авах хэн боловч миний нэрэнд итгэх болно; мөн түүнийг би чөлөөтэйгөөр өршөөх болно.

And he said unto the king: Behold, here are many whom we have brought before thee, who are accused of their brethren; yea, and they have been taken in divers iniquities. And they do not repent of their iniquities; therefore we have brought them before thee, that thou mayest judge them according to their crimes.

But king Mosiah said unto Alma: Behold, I judge them not; therefore I deliver them into thy hands to be judged.

And now the spirit of Alma was again troubled; and he went and inquired of the Lord what he should do concerning this matter, for he feared that he should do wrong in the sight of God.

And it came to pass that after he had poured out his whole soul to God, the voice of the Lord came to him, saying:

Blessed art thou, Alma, and blessed are they who were baptized in the waters of Mormon. Thou art blessed because of thy exceeding faith in the words alone of my servant Abinadi.

And blessed are they because of their exceeding faith in the words alone which thou hast spoken unto them.

And blessed art thou because thou hast established a church among this people; and they shall be established, and they shall be my people.

Yea, blessed is this people who are willing to bear my name; for in my name shall they be called; and they are mine.

And because thou hast inquired of me concerning the transgressor, thou art blessed.

Thou art my servant; and I covenant with thee that thou shalt have eternal life; and thou shalt serve me and go forth in my name, and shalt gather together my sheep.

And he that will hear my voice shall be my sheep; and him shall ye receive into the church, and him will I also receive.

For behold, this is my church; whosoever is baptized shall be baptized unto repentance. And whomsoever ye receive shall believe in my name; and him will I freely forgive.

23 Учир нь дэлхийн нүглийг өөр дээрээ авагч нь би билээ; учир нь тэднийг бүтээсэн нь би билээ; мөн төгсгөл хүртэл итгэх түүнд баруун гар талдаа байрлахыг соёрхох нь би билээ.

24 Учир нь болгоогтун, миний нэрээр тэд нэрлэгдэнэ; мөн хэрэв тэд намайг мэдэх аваас тэд гарч ирэх болно, мөн миний баруун гар тал дахь байрыг мөнхөд эзлэх болно.

25 Мөнхүү улиран тохиох дор хоёр дахь бүрээ дуугарахад тэгээд намайг огт мэдээгүй тэд урагш гарч мөн миний өмнө зогсох болно.

26 Мөн тэгээд би бол Их Эзэн тэдний Бурхан гэдгийг, би бол тэдний Гэтэлгэгч гэдгийг тэд мэдэх болно; гэвч тэд гэтэлгэгдэхээс татгалзсан болой.

27 Мөн тэгээд би тэднийг огт мэдээгүй хэмээн айлдах болно; мөн тэд чөтгөр болон түүний элчүүдэд бэлтгэгдсэн үүрдийн галд хаягдах болно.

28 Тиймийн тул би та нарт хэлнэ, миний дуу хоолойг сонсохгүй түүнийг, мөнхүү түүнийг та нар миний сүмд хүлээн авахгүй байх болно, учир нь түүнийг эцсийн өдөр би хүлээн авахгүй байх болно.

29 Тиймийн тул би чамд хэлнэ, Явагтун; мөн миний эсрэг зөрчил үйлдэх хэнийг боловч, түүнийг үйлдсэн тэр нүглүүдийнх нь дагуу та нар шүүх болно; мөн хэрэв тэр чиний мөн миний өмнө нүглүүдээ тоочиж, мөн чин зүрхнийхээ угаас наманчлах аваас, түүнийг та нар уучлах болно, мөн түүнчлэн би түүнийг өршөөх болно.

30 Тийм ээ, мөн миний хүмүүс наманчлах болгонд би тэднийг миний эсрэг алдаануудад нь өршөөх болно.

31 Мөн та нар түүнчлэн нэг нэгнийхээ алдаануудыг уучлах ёстой; учир нь үнэнээр би та нарт хэлнэ, наманчилж буйгаа хэлсээр байтал нь хөршийнхөө алдааг эс өршөөх тэр, мөнхүү тэр нь өөрийгөө буруутгалын дор авчирдаг бөлгөө.

32 Эдүгээ би чамд хэлнэ, Явагтун; мөн нүглүүдээ эс наманчлах хэн боловч тэр нь миний хүмүүсийн дунд тоологдох нь үгүй; мөн энэ цагаас хойшид энэ нь мөрдөгдөх болно.

For it is I that taketh upon me the sins of the world; for it is I that hath created them; and it is I that granteth unto him that believeth unto the end a place at my right hand.

For behold, in my name are they called; and if they know me they shall come forth, and shall have a place eternally at my right hand.

And it shall come to pass that when the second trump shall sound then shall they that never knew me come forth and shall stand before me.

And then shall they know that I am the Lord their God, that I am their Redeemer; but they would not be redeemed.

And then I will confess unto them that I never knew them; and they shall depart into everlasting fire prepared for the devil and his angels.

Therefore I say unto you, that he that will not hear my voice, the same shall ye not receive into my church, for him I will not receive at the last day.

Therefore I say unto you, Go; and whosoever transgresseth against me, him shall ye judge according to the sins which he has committed; and if he confess his sins before thee and me, and repenteth in the sincerity of his heart, him shall ye forgive, and I will forgive him also.

Yea, and as often as my people repent will I forgive them their trespasses against me.

And ye shall also forgive one another your trespasses; for verily I say unto you, he that forgiveth not his neighbor's trespasses when he says that he repents, the same hath brought himself under condemnation.

Now I say unto you, Go; and whosoever will not repent of his sins the same shall not be numbered among my people; and this shall be observed from this time forward.



- 33 Мөнхүү улиран тохиох дор Алма эдгээр үгсийг сонсоод тэдгээрийг өөртөө байлгаж болохын тулд, мөн сүмийн хүмүүсийг Бурханы зарлигуудын дагуу шүүж болохын тулд бичиж авсан бөлгөө.
- 34 Мөнхүү улиран тохиох дор Алма явж мөн алдаст баригдсан тэднийг Их Эзэний үгийн дагуу шүүв.
- 35 Мөн нүглүүдээ наманчилсан мөн тэдгээрийг хүлээсэн хэнийг боловч, тэрээр тэднийг сүмийн хүмүүсийн дунд тоолсон ажгуу;
- 36 Мөн нүглүүдээ хүлээгээгүй мөн алдсуудаа наманчлаагүй тэд, хэн боловч сүмийн хүмүүсийн дунд тоологддоггүй байж, мөн тэдний нэрс арилгагдсан байв.
- 37 Мөнхүү улиран тохиох дор Алма сүмийн бүх хэргүүдийг хянав; мөн тэд дахин амар амгалан байж мөн Бурханы өмнө хянамгайгаар алхаж, олныг хүлээн авч, мөн олонд баптисм хүртээн, сүмийн хэргүүдэд үлэмж дэгжиж эхлэв.
- 38 Мөн эдүгээ сүмийг удирдаж асан тэд болох Алма мөн түүний хамтран хөдөлмөрлөгчид хичээнгүйлэн явж, бүх зүйлд Бурханы үгсийг зааж, төрөл бүрийн зовлонгуудыг амсан, Бурханы сүмд хамаарагдаагүй тэд бүгдээр хавчигдан байж эдгээр бүх зүйлийг хийсэн болой.
- 39 Мөн тэд ах дүүсээ зэмлэв; мөн тэд түүнчлэн Бурханы үгээр, хүн бүр нүглүүдийнхээ дагуу, өөрөөр хэлбэл үйлдсэн тэр нүглүүддээ зэмлэгдэж байв, мөн тэд тасралтгүй залбирч, мөн бүх зүйлд талархал илэрхийлж байхыг Бурханаар зарлиг болгуулсны учир болой.

And it came to pass when Alma had heard these words he wrote them down that he might have them, and that he might judge the people of that church according to the commandments of God.

And it came to pass that Alma went and judged those that had been taken in iniquity, according to the word of the Lord.

And whosoever repented of their sins and did confess them, them he did number among the people of the church;

And those that would not confess their sins and repent of their iniquity, the same were not numbered among the people of the church, and their names were blotted out.

And it came to pass that Alma did regulate all the affairs of the church; and they began again to have peace and to prosper exceedingly in the affairs of the church, walking circumspectly before God, receiving many, and baptizing many.

And now all these things did Alma and his fellow laborers do who were over the church, walking in all diligence, teaching the word of God in all things, suffering all manner of afflictions, being persecuted by all those who did not belong to the church of God.

And they did admonish their brethren; and they were also admonished, every one by the word of God, according to his sins, or to the sins which he had committed, being commanded of God to pray without ceasing, and to give thanks in all things.

## Мозая 27

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор үл итгэгчдээс сүмд учруулах хавчлагууд үлэмж их болсон учир сүмийнхэн уг хэргийн талаар удирдагчиддаа бувтналдан, мөн гомдоллож эхлэв; мөн тэд Алмад гомдоллов. Мөн Алма өөрсдийн хаан, Мозаяд байдлыг танилцуулав. Мөн Мозая санваартнуудтайгаа зөвлөв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор хаан Мозая үл итгэгчдийн хэн нь ч Бурханы сүмд харъяалагдсан тэднээс хэнийг ч хавчих ёсгүй хэмээх тунхаг бичгийг эргэн тойрны нутаг даяар илгээв.
- 3 Мөн бүх сүмд тэдний дунд хавчлага байх ёсгүй, бүх хүмүүний дунд эрх тэгш байдал байх ёстой гэсэн чанд зарлиг байв.
- 4 Ямар ч бардамнал бас ямар ч ихэмсэглэл тэдний амар амгаланд саад учруулахыг тэд зөвшөөрөх ёсгүй; хүн бүр хөршөө өөрийнхөө адил хүндэтгэж, өөрсдийгөө тэтгэхийн тулд өөрийн гараар хөдөлмөрлөх ёстой байв.
- 5 Тийм ээ, мөн тэдний бүх санваартнууд мөн багш нар өвчний, эсвээс их гачигдлын байдлаас өөр ямар ч нөхцөлд тэд өөрсдийгөө тэжээхээр өөрсдийн гараар хөдөлмөрлөх ёстой; мөн эдгээр зүйлийг хийснээр Бурханы ач ивээлд умбасан болой.
- 6 Мөн уг нутагт дахин их амгалан байж эхлэв; мөн хүмүүс маш олон тоотой болж эхлэв, мөн газрын гадаргуу дээр тархаж эхлэв, тийм ээ, өмнөдөд мөн умардад, дорнодод бас өрнөдөд, уг нутгийн бүх хэсгүүдэд том хотууд мөн тосгод барьсан бөлгөө.
- 7 Мөн Их Эзэн тэдэнд зочилж мөн тэднийг дэгжүүлэн, мөн тэд өнөр өтгөн хийгээд чинээлэг хүмүүс болов.
- 8 Эдүгээ Мозаягийн хөвгүүд үл итгэгчдийн дунд тоологдож байв; мөн түүнчлэн Алмагийн хөвгүүдийн нэг нь тэдний дунд тоологдож байлаа, тэр эцгийнхээ адилаар Алма гэж нэрлэгдсэн байв; гэсэн хэдий ч, тэр маш ёс бус мөн хиймлийг шүтэгч хүн болов. Мөн тэрээр олон үгтэй хүн байж, мөн хүмүүст ихээхэн зусрыг ярьдаг байв; тиймийн тул тэрээр хүмүүсээс олныг нь өөрийн алдсуудын маягаар хийгийг удирдсан ажгуу.

## Mosiah 27

And now it came to pass that the persecutions which were inflicted on the church by the unbelievers became so great that the church began to murmur, and complain to their leaders concerning the matter; and they did complain to Alma. And Alma laid the case before their king, Mosiah. And Mosiah consulted with his priests.

And it came to pass that king Mosiah sent a proclamation throughout the land round about that there should not any unbeliever persecute any of those who belonged to the church of God.

And there was a strict command throughout all the churches that there should be no persecutions among them, that there should be an equality among all men;

That they should let no pride nor haughtiness disturb their peace; that every man should esteem his neighbor as himself, laboring with their own hands for their support.

Yea, and all their priests and teachers should labor with their own hands for their support, in all cases save it were in sickness, or in much want; and doing these things, they did abound in the grace of God.

And there began to be much peace again in the land; and the people began to be very numerous, and began to scatter abroad upon the face of the earth, yea, on the north and on the south, on the east and on the west, building large cities and villages in all quarters of the land.

And the Lord did visit them and prosper them, and they became a large and wealthy people.

Now the sons of Mosiah were numbered among the unbelievers; and also one of the sons of Alma was numbered among them, he being called Alma, after his father; nevertheless, he became a very wicked and an idolatrous man. And he was a man of many words, and did speak much flattery to the people; therefore he led many of the people to do after the manner of his iniquities.

- 9 Мөн тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлийг хулгайлан; хүмүүсийн дунд их зөрөлдөөнийг үүсгэж; тэдний дээр өөрийн хүчийг үзүүлэх боломжийг Бурханы дайсанд олгож байсан учир тэрээр Бурханы сүмийн хөгжилд үлэмж том саад болов.
- 10 Мөн эдүгээ улиран тохиох дор тэрээр Бурханы сүмийг устгахаар явж байхад нь, тодруулбал тэр Мозаягийн хөвгүүдтэй сүмийг устгахыг, мөн Их Эзэний хүмүүсийг буруу замд удирдахыг эрэлхийлэн, Бурханы, эсвээс бүр хааны зарлигуудын эсрэг нууцаар явдаг байлаа—
- 11 Мөн та нарт миний хэлсэнчлэн, тэд Бурханыг эсэргүүцэн явах зуур, болгоогтун, Их Эзэний тэнгэр элч тэдэнд үзэгдэв; мөн тэрээр үүлэнд байсан мэтээр доошлон ирэв; мөн тэрээр тэдний дээр нь зогсож байсан газрыг доргиход хүргэсэн аянгын дуу лугаа адил дуу хоолойгоор ярив;
- 12 Мөн тэдний сүрдэн гайхсан нь маш их байснаас, тэд газарт унаж, тэгээд өөрсдөд нь ярьсан түүний үгсийг ойлгосонгүй.
- 13 Гэсэн хэдий ч тэр дахин хашгирч, хэлрүүн: Алма, бос мөн урагш зогс, та яагаад Бурханы сүмийг хавчих болов? Учир нь: Энэ бол миний сүм, мөн би үүнийг төвхнүүлэх болно; мөн миний хүмүүсийн зөрчлөөс өөр юу ч үүнийг буулгахгүй хэмээн Их Эзэн хэлж байна.
- 14 Мөн түүнчлэн, тэнгэр элч хэлэв: Болгоогтун, Их Эзэн өөрийн хүмүүсийн залбирлуудыг, мөн түүнчлэн өөрийн үйлчлэгч, таны эцэг болох Алмагийн залбирлуудыг сонссон; учир нь та үнэний мэдлэгт авчрагдаж болохын тулд таны талаар их итгэлтэйгээр тэрээр залбирсан бөлгөө; тиймийн тул, энэ зорилгоор түүний үйлчлэгчдийн залбирлууд тэдний итгэлийнх нь дагуу хариулагдаж болохын тулд Бурханы хүч болон эрх мэдлийг танд итгүүлэхийн тулд ирлээ, би.
- 15 Мөн эдүгээ болгоогтун, та Бурханы хүчийг сөрж чадах уу? Учир нь болгоогтун, миний дуу хоолой газрыг доргиохгүй байна гэж үү? Мөн түүнчлэн та намайг өөрийнхөө өмнө харж чадаж байгаа бус уу? Мөн Бурханаас илгээгдсэн билээ, би.

And he became a great hinderment to the prosperity of the church of God; stealing away the hearts of the people; causing much dissension among the people; giving a chance for the enemy of God to exercise his power over them.

And now it came to pass that while he was going about to destroy the church of God, for he did go about secretly with the sons of Mosiah seeking to destroy the church, and to lead astray the people of the Lord, contrary to the commandments of God, or even the king—

And as I said unto you, as they were going about rebelling against God, behold, the angel of the Lord appeared unto them; and he descended as it were in a cloud; and he spake as it were with a voice of thunder, which caused the earth to shake upon which they stood;

And so great was their astonishment, that they fell to the earth, and understood not the words which he spake unto them.

Nevertheless he cried again, saying: Alma, arise and stand forth, for why persecutest thou the church of God? For the Lord hath said: This is my church, and I will establish it; and nothing shall overthrow it, save it is the transgression of my people.

And again, the angel said: Behold, the Lord hath heard the prayers of his people, and also the prayers of his servant, Alma, who is thy father; for he has prayed with much faith concerning thee that thou mightest be brought to the knowledge of the truth; therefore, for this purpose have I come to convince thee of the power and authority of God, that the prayers of his servants might be answered according to their faith.

And now behold, can ye dispute the power of God? For behold, doth not my voice shake the earth? And can ye not also behold me before you? And I am sent from God.

- 16 Эдүгээ би танд хэлье: Явагтун, мөн Хеладын нутагт, мөн Нифайн нутагт эцэг өвгөд тань боолчлолд байсныг санагтун; мөн тэдний төлөө тэрээр ямар агуу зүйлүүдийг хийснийг сана; учир нь тэд боолчлолд байсан тэгээд тэрээр тэднийг чөлөөлсөн юм. Мөн эдүгээ би танд хэлнэ, Алма, өөрийн замаар яв, мөн тэдний залбирал хариулагдаж болохын тулд сүмийг устгахыг дахин бүү эрэлхийл, мөн та өөрөө зайлуулагдахыг хүссэн ч, үүнийг бүү хийгтүн.
- 17 Мөн эдүгээ улиран тохиох дор эдгээр нь Алмад ярьсан тэнгэр элчийн сүүлчийн үгс байв, мөн тэрээр одов.
- 18 Мөн эдүгээ Алма болон түүнтэй хамт байсан тэд газарт унав, учир нь тэдний сүрдэн гайхсан нь асар их байв; учир нь Их Эзэний тэнгэр элчийг тэд нүдээр харсан болой; мөн түүний дуу газрыг доргиох аянга лугаа адил байв; мөн Бурханы хүчнээс өөр юу ч газрыг доргион мөн хоёр тийш болон хуваагдах мэт чичиргэж чадахгүйг тэд мэдсэн бөлгөө.
- 19 Мөн эдүгээ Алмагийн сүрдэн гайхширсан нь маш их байсан учир тэрээр хэлгүй болов, амаа ч нээж чадахгүй байлаа; тийм ээ, тэрээр доройтон бүр гараа ч хөдөлгөж чадахгүй болжээ; тиймийн тул тэрээр түүн лугаа адил байсан тэднээр өргөгдөж, мөн арчаагүйгээр зөөгдөн, бүр эцгийнхээ өмнө хэвтүүлэгдэх хүртлээ буюу.
- 20 Мөн тэд түүний эцэгт өөрсдөд нь тохиолдсон бүгдийг тоочин хэлэв; мөн түүний эцэг баясав, учир нь энэ бол Бурханы хүч байсныг тэрээр мэдэж байлаа.
- 21 Мөн тэрээр хүүд нь, мөн түүнчлэн түүнтэй байсан тэдэнд Их Эзэн юу хийснийг тэд гэрчилж болно хэмээн олон хүмүүнийг цуглуулав.
- 22 Мөн тэрээр санваартнуудыг нэгдэн чуулахаар болгов; тэрээр Алмагийн ам ярьж болохын тулд нээгдэж, мөн түүнчлэн түүний үе мөч хүчээ сэргээн авч болохын тулд—Бурханы сайн сайхан хийгээд алдар сууг мэдэж мөн харахаар хүмүүсийн нүд нээгдэж болохын тулд тэд мацаг барин, мөн Их Эзэн Бурхандаа хандан залбирч эхлэв.

Now I say unto thee: Go, and remember the captivity of thy fathers in the land of Helam, and in the land of Nephi; and remember how great things he has done for them; for they were in bondage, and he has delivered them. And now I say unto thee, Alma, go thy way, and seek to destroy the church no more, that their prayers may be answered, and this even if thou wilt of thyself be cast off.

And now it came to pass that these were the last words which the angel spake unto Alma, and he departed.

And now Alma and those that were with him fell again to the earth, for great was their astonishment; for with their own eyes they had beheld an angel of the Lord; and his voice was as thunder, which shook the earth; and they knew that there was nothing save the power of God that could shake the earth and cause it to tremble as though it would part asunder.

And now the astonishment of Alma was so great that he became dumb, that he could not open his mouth; yea, and he became weak, even that he could not move his hands; therefore he was taken by those that were with him, and carried helpless, even until he was laid before his father.

And they rehearsed unto his father all that had happened unto them; and his father rejoiced, for he knew that it was the power of God.

And he caused that a multitude should be gathered together that they might witness what the Lord had done for his son, and also for those that were with him.

And he caused that the priests should assemble themselves together; and they began to fast, and to pray to the Lord their God that he would open the mouth of Alma, that he might speak, and also that his limbs might receive their strength—that the eyes of the people might be opened to see and know of the goodness and glory of God.

- 23 Мөнхүү улиран тохиох дор тэд хоёр өдөр мөн хоёр шөнийн турш мацаг барьж, залбирсны дараа, Алмагийн үе мөчний хүч тамир сэргэж, мөн тэрээр дээш босоод, мөн тэднийг тайвшрахыг хүсэн тэдэнд ярьж эхлэв:
- 24 Учир нь, хэмээн тэрээр хэлж, би нүглүүдээ наманчилсан, мөн Их Эзэнээр гэтэлгэгдсэн; болгоогтун би Сүнсээр төрлөө гэв.
- 25 Мөн Их Эзэн надад хэлэв: Бүх хүн төрөлхтөн, тийм ээ, эрчүүд мөн эмэгтэйчүүд, бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс дахин төрөх ёстойд бүү гайх; тийм ээ, Бурханаар төрж, эгэл хийгээд унасан байдалаасаа зөв шударга байдалд орж өөрчлөгдөн, Бурханаар гэтэлгэгдэн, түүний хөвгүүд мөн охид болдог;
- 26 Мөн тийн тэд шинэ бүтээлүүд болдог; мөн үүнийг хийхгүйгээр, тэд Бурханы хаант улсыг өвлөж чадах аргагүй бөлгөө.
- 27 Би та нарт хэлнэ, энэ нөхцөлд бус аваас, тэд зайлуулагдах ёстой; мөн үүнийг би мэднэ, учир нь би зайлуулагдах дөхлөө.
- 28 Гэсэн хэдий ч, их бэрхшээлийг туулж үхэх дөхөн наманчилсны дараа, Их Эзэн намайг нигүүлсэлдээ үүрдийн шаталтаас шүүрч авах нь зохистой хэмээн үзжээ, мөн би Бурханаар төрлөө.
- 29 Миний бодгаль шаналлын гүн болон алдсын хүлээснээс гэтэлгэгдлээ. Би хамгийн харанхуй ангалд байсан; харин эдүгээ би Бурханы гайхамшигт гэрлийг харнам. Бодгаль минь мөнхийн зовлонд тарчилж байв; гэвч би шүүрэгдлээ, мөн бодгаль минь цаашид дахин өвдөх нь үгүй.
- 30 Би өөрийн Гэтэлгэгчийг эсэргүүцсэн, мөн бидний эцэг өвгөдөөр яригдсаныг үгүйсгэсэн; харин эдүгээ тэр ирэх болно, мөн тэрээр өөрийн бүтээсэн бүтээл бүрийг санана гэдгийг тэд урьдаас харж болохын тулд тэр өөрийгөө бүгдэд үзүүлэх болно.

And it came to pass after they had fasted and prayed for the space of two days and two nights, the limbs of Alma received their strength, and he stood up and began to speak unto them, bidding them to be of good comfort:

For, said he, I have repented of my sins, and have been redeemed of the Lord; behold I am born of the Spirit.

And the Lord said unto me: Marvel not that all mankind, yea, men and women, all nations, kindreds, tongues and people, must be born again; yea, born of God, changed from their carnal and fallen state, to a state of righteousness, being redeemed of God, becoming his sons and daughters;

And thus they become new creatures; and unless they do this, they can in nowise inherit the kingdom of God.

I say unto you, unless this be the case, they must be cast off; and this I know, because I was like to be cast off.

Nevertheless, after wading through much tribulation, repenting nigh unto death, the Lord in mercy hath seen fit to snatch me out of an everlasting burning, and I am born of God.

My soul hath been redeemed from the gall of bitterness and bonds of iniquity. I was in the darkest abyss; but now I behold the marvelous light of God. My soul was racked with eternal torment; but I am snatched, and my soul is pained no more.

I rejected my Redeemer, and denied that which had been spoken of by our fathers; but now that they may foresee that he will come, and that he remembereth every creature of his creating, he will make himself manifest unto all.

31 Тийм ээ, түүний өмнө өвдөг бүхэн сөхөрч, мөн хэл бүхэн хүлээн зөвшөөрөх болно. Тийм ээ, бүх хүмүүн түүгээр шүүгдэхээр зогсох бүр тэрхүү эцсийн өдөр, тэгээд тэр бол Бурхан гэдгийг тэд хүлээн зөвшөөрнө; тэгээд Бурхангүйгээр дэлхийд амьдрах тэд, тэдний дээрх үүрдийн шийтгэлийн шүүлт шударга болохыг хүлээн зөвшөөрнө; мөн тэд дагжин, мөн чичирч, мөн бүхнийг ухаарах түүний мэлмийн харцнаас навтайх болно.

32 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма болон Алмагийн хамт байсан тэд тэнгэр элч тэдэнд үзэгдсэн тэр цагт, энэ цагаас хойш хүмүүст сургаж эхлэв, мөн, бүх нутаг даяар аялан явж, үл итгэгчдэд ихээр хавчигдаж, тэдний олноор нь цохигдон, өөрсдийн сонссон мөн үзсэн тэр зүйлүүдээ бүх хүмүүнд тунхаглаж, мөн Бурханы үгийг их бэрхшээлийн дунд номлон байв.

33 Харин энэ бүгд байсан хэдий ч тэд сүмд их тайтгарлыг хайрласан болой, тэдний итгэлийг нь батлан, мөн тэсвэртэйгээр мөн ихэд шаргуугаар Бурханы зарлигуудыг дагахыг тэдэнд ухуулж байв.

34 Мөн тэдний дөрөв нь Мозаягийн хөвгүүд байв; мөн тэдний нэрс нь Аммон, мөн Аарон, мөн Омнер, мөн Химнай байв; эдгээр нь Мозаягийн хөвгүүдийн нэрс байв.

35 Мөн тэд Зарахемлагийн бүх нутгаар аялж, мөн хаан Мозаягийн засаглал дор байх бүх хүмүүсийн дунд, бүх нүглүүдээ хүлээж, мөн үзсэн тэр бүх зүйлүүдээ тунхаглан, мөн өөрсдийг нь сонсохыг хүссэн бүхэнд бошиглолууд хийгээд судруудыг тайлбарлаж, сүмд учруулсан тэр бүх хор хөнөөлөө залруулахаар хичээж байв.

36 Мөн тийн тэд олныг үнэний мэдлэгт, тийм ээ, Гэтэлгэгчийнхээ мэдлэгт авчрахад Бурханы мутардахь зэмсгүүд болов.

37 Мөн эдүгээ хичнээн их адислагдсан билээ тэд! Учир нь амар амгаланг тэд тунхагласан болой; баярт мэдээг тэд тунхагласан болой; мөн Их Эзэн хаанчилдгийг тэд хүмүүст зарлан мэдэгдсэн билээ.

Yea, every knee shall bow, and every tongue confess before him. Yea, even at the last day, when all men shall stand to be judged of him, then shall they confess that he is God; then shall they confess, who live without God in the world, that the judgment of an everlasting punishment is just upon them; and they shall quake, and tremble, and shrink beneath the glance of his all-searching eye.

And now it came to pass that Alma began from this time forward to teach the people, and those who were with Alma at the time the angel appeared unto them, traveling round about through all the land, publishing to all the people the things which they had heard and seen, and preaching the word of God in much tribulation, being greatly persecuted by those who were unbelievers, being smitten by many of them.

But notwithstanding all this, they did impart much consolation to the church, confirming their faith, and exhorting them with long-suffering and much travail to keep the commandments of God.

And four of them were the sons of Mosiah; and their names were Ammon, and Aaron, and Omner, and Himni; these were the names of the sons of Mosiah.

And they traveled throughout all the land of Zarahemla, and among all the people who were under the reign of king Mosiah, zealously striving to repair all the injuries which they had done to the church, confessing all their sins, and publishing all the things which they had seen, and explaining the prophecies and the scriptures to all who desired to hear them.

And thus they were instruments in the hands of God in bringing many to the knowledge of the truth, yea, to the knowledge of their Redeemer.

And how blessed are they! For they did publish peace; they did publish good tidings of good; and they did declare unto the people that the Lord reigneth.

## Мозая 28

- 1 Эдүгээ улиран тохиох дор Мозаягийн хөвгүүд эдгээр бүх зүйлийг хийсний дараа тэд өөрсөдтэйгөө цөөн тооны хүмүүсийг авч мөн хаан эцэгтээ эргэж очив, мөн тэднийг, сонгож авсан тэдэнтэйгээ хамт, тэд сонссон зүйлүүдээ номлож, мөн тэд Бурханы үгийг өөрсдийн ахан дүүс, леменчүүдэд хүргэж болохын тулд Нифайн нутаг өөд явахыг зөвшөөрөөч хэмээн түүнээс хүсэв—
- 2 Тэднийг Их Эзэн Бурханых нь мэдлэгт тэд авчирч, мөн эцэг өвгөдийнх нь алдсыг тэдэнд ойлгуулж магадгүйн учир буюу; мөн Их Эзэн Бурханых нь тэдэнд өгсөн бүх нутагт зөрчилдөөнүүд дахин байхгүйн төлөө, тэд нэг нэгэнтэйгээ найрсаг болж болохын тулд, түүнчлэн Их Эзэн Бурхандаа баясахаар тэд хүргэгдэж болохын тулд, нифайчуудад хандсан тэдний үзэн ядалтыг тэд анагааж магадгүйн учир болой.
- 3 Эдүгээ аврал бүтээл бүрд тунхаглагдвал зохино хэмээх хүсэл тэдэнд байв, учир нь тэд аль ч хүмүүний бодгаль мөхнө гэдгийг тэвчиж үл чадах байсан ажгуу; тийм ээ, бүр ямар нэгэн бодгаль төгсгөлгүй тарчлалыг амсана гэдэг чухам тэрхүү бодлууд тэднийг чичирч мөн дагжихад хүргэсэн ажээ.
- 4 Мөн Их Эзэний Сүнс тэдний дээр тийн үйлдсэн болой, учир нь тэд адгийн нүгэлтнүүд байв. Мөн Их Эзэн хязгааргүй нигүүлсэлдээ тэднийг хэлтрүүлбэл зохино хэмээн үзэв; гэсэн хэдий ч тэд алдсуудынхаа учир бодгалийн их тарчлалыг амсаж, тэд үүрд зайлуулагдахвий хэмээн ихэд зовж мөн айж байв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Нифайн нутаг өөд явж болохын тулд тэд эцгээсээ олон хоног гуйсан аж.
- 6 Мөн хаан Мозая явж мөн тэр хөвгүүдээ үгийг номлохоор леменчүүдийн дунд явахыг нь зөвшөөрөх эсэхээ Их Эзэнээс лавлав.
- 7 Мөн Их Эзэн Мозаяд хэлэв: Тэднийг явахыг зөвшөөрөгтүн, учир нь олон нь тэдний үгсэд итгэх болно, мөн тэд мөнх амьдралыг авах болно; мөн би хөвгүүдийг чинь леменчүүдийн гараас чөлөөлөх болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд хүссэнийхээ дагуу яван мөн хийж болно хэмээн Мозая зөвшөөрөв.

## Mosiah 28

Now it came to pass that after the sons of Mosiah had done all these things, they took a small number with them and returned to their father, the king, and desired of him that he would grant unto them that they might, with these whom they had selected, go up to the land of Nephi that they might preach the things which they had heard, and that they might impart the word of God to their brethren, the Lamanites—

That perhaps they might bring them to the knowledge of the Lord their God, and convince them of the iniquity of their fathers; and that perhaps they might cure them of their hatred towards the Nephites, that they might also be brought to rejoice in the Lord their God, that they might become friendly to one another, and that there should be no more contentions in all the land which the Lord their God had given them.

Now they were desirous that salvation should be declared to every creature, for they could not bear that any human soul should perish; yea, even the very thoughts that any soul should endure endless torment did cause them to quake and tremble.

And thus did the Spirit of the Lord work upon them, for they were the very vilest of sinners. And the Lord saw fit in his infinite mercy to spare them; nevertheless they suffered much anguish of soul because of their iniquities, suffering much and fearing that they should be cast off forever.

And it came to pass that they did plead with their father many days that they might go up to the land of Nephi.

And king Mosiah went and inquired of the Lord if he should let his sons go up among the Lamanites to preach the word.

And the Lord said unto Mosiah: Let them go up, for many shall believe on their words, and they shall have eternal life; and I will deliver thy sons out of the hands of the Lamanites.

And it came to pass that Mosiah granted that they might go and do according to their request.

- 9 Мөн тэд леменчүүдийн дунд үгийг номлохоор яван аглаг буйд тийш аянаа хөөв; мөн тэдний цаашдын үйлүүдийн шастирыг би хожим өгөх болно.
- 10 Эдүгээ хаант улсыг шилжүүлэх хүн хаан Мозаяд байсангүй, учир нь түүний хөвгүүдээс хаант улсыг хүлээн авах хэн нь ч байсангүй.
- 11 Тиймийн тул тэрээр Лимхайн гараар түүнд хүргэгдсэн, Лимхайн хүмүүсээр олдсон алтан ялтсууд дээр байсан цэдгүүдийг орчуулуулж мөн бичүүлсний дараа тэрээр гуулин ялтсууд, мөн түүнчлэн Нифайн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн цэдгүүдийг мөн Бурханы зарлигуудын дагуу өөрийн хадгалж мөн хамгаалж үлдээсэн бүх зүйлийг авчээ;
- 12 Мөн хүмүүсийнхээ агуу их зовнилын учир тэр үүнийг хийв; учир нь тэд устгагдсан тэдгээр хүмүүсийн талаар мэдэх хэмжээлшгүй хүсэлтэй байв.
- 13 Мөн эдүгээ тэрээр тал дугаргийн хоёр хүрээнд суулгасан тэрхүү хоёр чулууны тусламжтайгаар орчуулав.
- 14 Эдүгээ эдгээр зүйлүүд эхлэлээс бэлтгэгдсэн ажээ, мөн хэлнүүдийг хөрвүүлэх зорилгын учир үеэс үед гардуулагдсан байв.
- 15 Мөн тэдгээр нь Их Эзэний мутраар хамгаалагдаж мөн хадгалагдан үлдсэн ажгуу, тэрээр өөрийн хүмүүсийн алдсууд мөн жигшүүрт хэргүүдийг уг нутгийг эзэмших бүтээл бүрд мэдүүлэхийн тулд бөлгөө.
- 16 Мөн эдгээр зүйлүүд өөрт нь байгаа хэн боловч, хуучин цагийн заншлаар үзмэрч гэж нэрлэгдэх буюу.
- 17 Эдүгээ Мозая эдгээр цэдгүүдийг орчуулж дууссаны дараа, болгоогтун, энэ нь устгагдсан хүмүүсийн шастирыг өгүүлдэг, тэдний устгагдсан үеэс урагш тэд агуу цамхаг барих хүртэл, Их Эзэн хүмүүсийн хэлийг будлиулж мөн тэд бүх дэлхийн гадаргуугаар нэг тархсан тэр цагт ажгуу, тийм ээ, мөн бүр тэр цагаас урагш Адамыг бүтээсэн цаг хүртэл бөлгөө.
- 18 Эдүгээ энэ шастир Мозаягийн хүмүүсийг үлэмж гашуудахад хүргэв, тийм ээ, тэд харамслаар дүүрэн байв; гэсэн хэдий ч, тэр их мэдлэгийг тэдэнд өгсөн нь тэднийг баясгах бөлгөө.

And they took their journey into the wilderness to go up to preach the word among the Lamanites; and I shall give an account of their proceedings hereafter.

Now king Mosiah had no one to confer the kingdom upon, for there was not any of his sons who would accept of the kingdom.

Therefore he took the records which were engraven on the plates of brass, and also the plates of Nephi, and all the things which he had kept and preserved according to the commandments of God, after having translated and caused to be written the records which were on the plates of gold which had been found by the people of Limhi, which were delivered to him by the hand of Limhi;

And this he did because of the great anxiety of his people; for they were desirous beyond measure to know concerning those people who had been destroyed.

And now he translated them by the means of those two stones which were fastened into the two rims of a bow.

Now these things were prepared from the beginning, and were handed down from generation to generation, for the purpose of interpreting languages;

And they have been kept and preserved by the hand of the Lord, that he should discover to every creature who should possess the land the iniquities and abominations of his people;

And whosoever has these things is called seer, after the manner of old times.

Now after Mosiah had finished translating these records, behold, it gave an account of the people who were destroyed, from the time that they were destroyed back to the building of the great tower, at the time the Lord confounded the language of the people and they were scattered abroad upon the face of all the earth, yea, and even from that time back until the creation of Adam.

Now this account did cause the people of Mosiah to mourn exceedingly, yea, they were filled with sorrow; nevertheless it gave them much knowledge, in the which they did rejoice.



19 Мөн энэхүү шастир хожим бичиглэгдэх болно; учир нь болгоогтун, энэ шастирт бичигдсэн зүйлийг бүх хүмүүс мэдэх нь чухал болой.

20 Мөн эдүгээ, би та нарт хэлсэнчлэн, хаан Мозая эдгээр зүйлийг хийснийхээ дараа, гуулин ялтсуудыг, мөн өөрийн хадгалсан бүх зүйлийг тэрээр авсан аж, мөн тэдгээрийг Алмагийн хүү Алмагийн мэдэлд тэр шилжүүлэв; тийм ээ, бүх цэдэг, мөн түүнчлэн хөрвүүлэгчдийг, мөн тэдгээрийг түүний мэдэлд шилжүүлж, мөн тэрээр тэдгээрийг хамгаалж мөн хадгалан үлдээж, мөн түүнчлэн хүмүүсийн цэдгийг хөтөлж, бүр тэд Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас тэдгээр нь доош гардуулагдаж байсны адил тэдгээрийг нэг үеэс нөгөөд гардуулж байхыг түүнд зарлиг болгов.

And this account shall be written hereafter; for behold, it is expedient that all people should know the things which are written in this account.

And now, as I said unto you, that after king Mosiah had done these things, he took the plates of brass, and all the things which he had kept, and conferred them upon Alma, who was the son of Alma; yea, all the records, and also the interpreters, and conferred them upon him, and commanded him that he should keep and preserve them, and also keep a record of the people, handing them down from one generation to another, even as they had been handed down from the time that Lehi left Jerusalem.

## Мозая 29

- 1 Эдүгээ Мозая үүнийг хийснийхээ дараа бүх нутаг даяар, бүх хүмүүсийн дунд, хэн тэдний хаан байвал зохих талаар тэдний хүслийг мэдэхийг хүсэн илгээв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал ирж, өгүүлсэн нь: Бид таны хүү Аарон бидний хаан хийгээд бидний захирагч байхыг хүсч байна.
- 3 Эдүгээ Аарон Нифайн нутаг өөд явсан байв, тиймийн тул хаан түүний мэдэлд хаант улсыг шилжүүлж чадсангүй; Аарон ч хаант улсыг өөртөө авахыг хүссэнгүй; Мозаягийн хөвгүүдийн аль нь ч хаант улсыг өөрсөд дээрээ авахыг таалсангүй ажгуу.
- 4 Тиймийн тул хаан Мозая хүмүүсийн дунд дахин илгээж; тийм ээ, бүр бичиглэгдсэн үгийг хүмүүсийн дунд илгээв. Мөн эдгээр нь бичигдсэн тэрхүү үгс буюу, өгүүлсэн нь:
- 5 Болгоогтун, Ай хүмүүс та нар минь, өөрөөр хэлбэл ах дүүс минь, учир нь би та нарыг тийнхүү хүндэтгэн үзнэ, та нар эрэгцүүлэхийн тулд дуудагдсан тэрхүү байдлыг эрэгцүүлж үзвэл зохино хэмээн би хүснэ—учир нь та нар хаантай байх хүсэлтэй буюу.
- 6 Эдүгээ хаант улс зүй ёсоор харьяалагдах ёстой тэр нь тагталзлаа, мөн хаант улсыг тэр өөр дээрээ эс авах болно гэдгийг би та нар т зарлая.
- 7 Мөн эдүгээ хэрэв түүний оронд өөр нэг нь томилогдох аваас, болгоогтун би та нарын дунд зөрчилдөөн гарах вий хэмээн айна. Мөн хэн мэдэх билээ, энэ хаант улс харьяалагдах ёстой байсан миний хүү, зангаа хувирган уурлаж мөн энэ хүмүүсийн нэг хэсгийг өөрийн хойноос дагуулж одох вий, тэгвэл та нарын дунд дайнууд мөн зөрчилдөөнүүд үүсч, тэгснээр их цус урсан, мөн Их Эзэний замыг гажуудуулахад хүргэн, тийм ээ, мөн олон хүмүүний бодгалийг устгаж болзошгүй буюу.
- 8 Эдүгээ би та нар т хэлнэ, ухаалаг байцгаая мөн эдгээр зүйлийг эргэцүүлэн бодоцгооё, учир нь миний хүүг устгах эрх бидэнд үгүй, мөн хэрэв түүний оронд өөр нэг нь тохоогдвол түүнийг устгах эрх ч бас бидэнд үгүй.

## Mosiah 29

Now when Mosiah had done this he sent out throughout all the land, among all the people, desiring to know their will concerning who should be their king.

And it came to pass that the voice of the people came, saying: We are desirous that Aaron thy son should be our king and our ruler.

Now Aaron had gone up to the land of Nephi, therefore the king could not confer the kingdom upon him; neither would Aaron take upon him the kingdom; neither were any of the sons of Mosiah willing to take upon them the kingdom.

Therefore king Mosiah sent again among the people; yea, even a written word sent he among the people. And these were the words that were written, saying:

Behold, O ye my people, or my brethren, for I esteem you as such, I desire that ye should consider the cause which ye are called to consider—for ye are desirous to have a king.

Now I declare unto you that he to whom the kingdom doth rightly belong has declined, and will not take upon him the kingdom.

And now if there should be another appointed in his stead, behold I fear there would rise contentions among you. And who knoweth but what my son, to whom the kingdom doth belong, should turn to be angry and draw away a part of this people after him, which would cause wars and contentions among you, which would be the cause of shedding much blood and perverting the way of the Lord, yea, and destroy the souls of many people.

Now I say unto you let us be wise and consider these things, for we have no right to destroy my son, neither should we have any right to destroy another if he should be appointed in his stead.

- 9 Мөн хэрэв миний хүү бардамнал мөн хоосон зүйлүүддээ дахин эргэх аваас тэр хэлсэн тэр зүйлүүддээсээ буцан, мөн хаант улс дахь өөрийн эрхийг шаардах нь, түүнийг мөн түүнчлэн энэ хүмүүсийг их нүгэл үйлдэхэд хүргэх бөлгөө.
- 10 Мөн эдүгээ ухаалаг байцгаая мөн эдгээр зүйлийг урьдаас харцгаая, мөн энэ хүмүүсийн амар амгаланг тогтоох зүйл хийцгээе.
- 11 Тиймийн тул би өөрийн өдрүүдийн үлдсэн хугацаанд та нарын хаан байх болно; гэсэн хэдий ч, манай хуулийн дагуу энэ хүмүүсийг шүүх шүүгчдийг томилцгооё; мөн бид энэ хүмүүсийн хэрэг явдлыг шинээр журамлах болно, учир нь Бурханы зарлигуудын дагуу энэ хүмүүсийг шүүх мэргэн хүмүүсийг шүүгчид байхаар бид томилох болно.
- 12 Эдүгээ хүн хүнээр шүүгдсэнээс Бурханаар шүүгдсэн нь дээр, учир нь Бурханы шүүлтүүд үргэлж шударга, харин хүний шүүлтүүд үргэлж шударга байдаггүй.
- 13 Тиймийн тул, хэрэв та нар Бурханы хуулиудыг тогтоож, мөн энэ хүмүүсийг түүний зарлигуудын дагуу шүүх шударга хүмүүсийг хаанаа болгож чадах нь боломжтой байсан аваас, тийм ээ, хэрэв та нар бүр миний эцэг Бенжамин энэ хүмүүсийн төлөө хийсний адилаар хийх хүмүүсийг хаадаа болгож чадах юм бол—Би та нарт хэлнэ, хэрэв энэ нь үргэлж ийм байдалд байж чаддаг сан бол та нар өөрсдийн дээр захирах хааныг үргэлж байлгах нь зүйд нийцэх бөлгөө.
- 14 Мөн та нарт Бурханы зарлигуудыг сургахаар, мөн дайн бас зөрчилдөөн, хулгай, дээрэм, аллага, бас аливаа алдсуудыг байлгахгүйн тулд уг нутаг даяар амар амгаланг тогтоохоор би өөрөө хүртэл эзэмшиж буй бүх хүч мөн чадлаараа хөдөлмөрлөсөөр ирсэн бөлгөө;
- 15 Мөн алдсыг үйлдсэн хэнийг боловч, түүнийг бас түүний үйлдсэн гэмт хэргийнх нь дагуу, эцэг өвгөдөөр маань бидэнд өгөгдсөн хуулийн дагуу би шийтгэж ирсэн билээ.
- 16 Эдүгээ би та нарт хэлнэ, хүн бүхэн шударга биш учраас та нар хаан эсвээс хаадыг өөрсдийн дээр захируулах нь зохистой бус бөлгөө.

And if my son should turn again to his pride and vain things he would recall the things which he had said, and claim his right to the kingdom, which would cause him and also this people to commit much sin.

And now let us be wise and look forward to these things, and do that which will make for the peace of this people.

Therefore I will be your king the remainder of my days; nevertheless, let us appoint judges, to judge this people according to our law; and we will newly arrange the affairs of this people, for we will appoint wise men to be judges, that will judge this people according to the commandments of God.

Now it is better that a man should be judged of God than of man, for the judgments of God are always just, but the judgments of man are not always just.

Therefore, if it were possible that you could have just men to be your kings, who would establish the laws of God, and judge this people according to his commandments, yea, if ye could have men for your kings who would do even as my father Benjamin did for this people—I say unto you, if this could always be the case then it would be expedient that ye should always have kings to rule over you.

And even I myself have labored with all the power and faculties which I have possessed, to teach you the commandments of God, and to establish peace throughout the land, that there should be no wars nor contentions, no stealing, nor plundering, nor murdering, nor any manner of iniquity;

And whosoever has committed iniquity, him have I punished according to the crime which he has committed, according to the law which has been given to us by our fathers.

Now I say unto you, that because all men are not just it is not expedient that ye should have a king or kings to rule over you.

17 Учир нь болгоогтун, нэгэн ёс бус хаан ямар их алдсыг, тийм ээ, мөн ямар агуу их устгалыг үйлдүүлэх билээ!

18 Тийм ээ, хаан Ноаг, түүний ёс бус үйлүүд хийгээд түүний жигшүүрт хэргүүдийг, мөн түүнчлэн түүний хүмүүсийн ёс бус үйлүүд хийгээд жигшүүрт хэргүүдийг санагтун. Ямар аймшигт устгал тэдэн дээр ирснийг болгоогтун; мөн түүнчлэн алдсуудынхаа учир боолчлолд оруулагдсан бөлгөө тэд.

19 Мөн бүхнээс мэргэн тэдний Бүтээгч оролцоогүй аваас мөн тэдний чин сэтгэлийн наманчлалын учир бус аваас, одоог хүртэл тэд гарцаагүй боолчлолд үлдэх ёстой байсан билээ.

20 Гэвч болгоогтун, тэд өөрсдийгөө түүний өмнө даруусгасны учир тэднийг тэрээр чөлөөлсөн юм; мөн тэд түүнд хүчтэйгээр гуйж залбирсан учир тэрээр тэднийг боолчлолоос чөлөөлсөн юм; мөн найдлагаа түүнд тавих тэдний зүг Их Эзэн нигүүлслийн мутраа сунгаж хүмүүний үрсийн дунд бүх нөхцөлд ийн ажилладаг.

21 Мөн болгоогтун, эдүгээ би та нарт хэлнэ, та нар алдсыг үйлдэгч хааныг их тэмцэл, мөн их цус урсгалтгүйгээр буулгаж чадахгүй.

22 Учир нь болгоогтун, алдастаа тэрээр өөрийн найзуудтай, мөн өөрийгөө хүрээлүүлэн харуулуудыг байлгадаг; мөн түүний өмнө зөв шударгаар засаглаж байсан тэдний хуулийг тэр урж тасчсан; мөн Бурханы зарлигуудыг тэр хөл дороо дэвсэлдэг.

23 Мөн тэр хуулиудыг тийм ээ, түүний өөрийнх нь ёсон бусын дагуух хуулиудыг тогтоож, мөн тэдгэрийг хүмүүсийнхээ дунд илгээдэг; мөн түүний хуулиудыг дагаагүй хэнийг боловч тэр устгадахаар болгоно; мөн түүний эсрэг тэмцсэн хэнд боловч их цэргээ тэдний эсрэг байлдуулахаар тэрээр илгээж, мөн хэрэв тэр чадвал тэднийг устгах болно; мөн тийн зөв шударга бус нэгэн хаан бүх зөв шударгын замуудыг гажуудуулдаг буюу.

24 Мөн эдүгээ болгоогтун би та нарт хэлнэ, та нарын дээр ийм жигшүүрт хэргүүд ирэх нь зүйд нийцэхгүй бөлгөө.

For behold, how much iniquity doth one wicked king cause to be committed, yea, and what great destruction!

Yea, remember king Noah, his wickedness and his abominations, and also the wickedness and abominations of his people. Behold what great destruction did come upon them; and also because of their iniquities they were brought into bondage.

And were it not for the interposition of their all-wise Creator, and this because of their sincere repentance, they must unavoidably remain in bondage until now.

But behold, he did deliver them because they did humble themselves before him; and because they cried mightily unto him he did deliver them out of bondage; and thus doth the Lord work with his power in all cases among the children of men, extending the arm of mercy towards them that put their trust in him.

And behold, now I say unto you, ye cannot dethrone an iniquitous king save it be through much contention, and the shedding of much blood.

For behold, he has his friends in iniquity, and he keepeth his guards about him; and he teareth up the laws of those who have reigned in righteousness before him; and he trampleth under his feet the commandments of God;

And he enacteth laws, and sendeth them forth among his people, yea, laws after the manner of his own wickedness; and whosoever doth not obey his laws he causeth to be destroyed; and whosoever doth rebel against him he will send his armies against them to war, and if he can he will destroy them; and thus an unrighteous king doth pervert the ways of all righteousness.

And now behold I say unto you, it is not expedient that such abominations should come upon you.

- 25 Тиймийн тул, зөв болох, мөн Их Эзэний мутраар тэдэнд өгөгдсөн, мөн эцэг өвгөдөөр маань бидэнд өгөгдсөн хуулиудын дагуу та нар шүүгдэж болохын тулд та нар энэ хүмүүсийн саналаар шүүгчдийг сонгогтун.
- 26 Эдүгээ хүмүүсийн санал зөв зүйлийн эсрэгийг хүсэх нь нийтлэг биш байдаг; харин хүмүүсийн цөөнх хэсэг нь зөв бус зүйлийг хүсэх нь элбэг; тиймийн тул үүнийг та нар даган мөн үүнийг—ажил хэргээ хүмүүсийн саналаар хийхийг хуулиа болгох болно.
- 27 Мөн хэрэв хүмүүсийн санал алдсыг сонгох цаг ирвэл, Бурханы шүүлтүүд та нарын дээр ирэх цаг нь тэр болой; тийм ээ, тэрээр бүр үүнээс урьд энэ нутагт зочилсны адил аймшигт устгалаар та нарын дээр зочлох цаг нь тэр болно.
- 28 Мөн эдүгээ хэрэв та нарт шүүгчид байвал, мөн тэд та нарыг өгөгдсөн тэр хуулийн дагуу шүүхгүй бол, та нар тэднийг илүү дээд шүүгчээр шүүлгэхээр болгож чадна.
- 29 Хэрэв танай илүү дээд шүүгчид зөв шударга шүүлтүүдээр шүүхгүй бол, та нар цөөн тооны доод шүүгчдийг нэгтгэн цуглуулж, мөн тэд танай дээд шүүгчдийг хүмүүсийн саналын дагуу шүүх болно.
- 30 Мөн Их Эзэнээс эмээх айдсандаа эдгээр зүйлийг хийхийг би та нарт зарлиг болгоно; мөн эдгээр зүйлийг хий мөн та нар хаангүй бай хэмээн би та нарт зарлиг болно; хэрэв эдгээр хүмүүс нүгэл болоод алдсуудыг үйлдвэл тэдгээр нь өөрсдийнх нь толгой дээр хариулагдах болно.
- 31 Учир нь болгоогтун би та нарт хэлнэ, олон хүмүүний нүглүүд тэдний хаадын алдсаас болсон байдаг; тиймийн тул тэдний алдсууд хаадынх нь толгой дээр хариулагддаг.
- 32 Мөн эдүгээ энэ тэгш бус байдал энэ нутагт, ялангуяа энэ миний хүмүүсийн дунд дахин бүү байгаасай хэмээн хүснэ би; харин энэ нутаг эрх чөлөөний нутаг байж, мөн хүн бүр өөрийн эрх мөн адил боломжуудыг адилхан эдлээсэй хэмээн хүснэ би, бид амьдарч мөн уг нутгийг өвлөж болох нь хэдий хэр хугацаанд зохистой хэмээн Их Эзэн үзнэ, тийм ээ, бүр бидний үр удмын аливаа үлдэгдлүүд уг нутгийн гадаргуу дээр оршин байх тэр хугацааны турш буюу.

Therefore, choose you by the voice of this people, judges, that ye may be judged according to the laws which have been given you by our fathers, which are correct, and which were given them by the hand of the Lord.

Now it is not common that the voice of the people desireth anything contrary to that which is right; but it is common for the lesser part of the people to desire that which is not right; therefore this shall ye observe and make it your law—to do your business by the voice of the people.

And if the time comes that the voice of the people doth choose iniquity, then is the time that the judgments of God will come upon you; yea, then is the time he will visit you with great destruction even as he has hitherto visited this land.

And now if ye have judges, and they do not judge you according to the law which has been given, ye can cause that they may be judged of a higher judge.

If your higher judges do not judge righteous judgments, ye shall cause that a small number of your lower judges should be gathered together, and they shall judge your higher judges, according to the voice of the people.

And I command you to do these things in the fear of the Lord; and I command you to do these things, and that ye have no king; that if these people commit sins and iniquities they shall be answered upon their own heads.

For behold I say unto you, the sins of many people have been caused by the iniquities of their kings; therefore their iniquities are answered upon the heads of their kings.

And now I desire that this inequality should be no more in this land, especially among this my people; but I desire that this land be a land of liberty, and every man may enjoy his rights and privileges alike, so long as the Lord sees fit that we may live and inherit the land, yea, even as long as any of our posterity remains upon the face of the land.

33 Мөн шударга хааны бүх сорилт мөн бэрхшээлүүдийг тэдэнд дэлгэн, мөн илүү олон зүйлийг, тийм ээ, хүмүүсийнхээ төлөө гэх бүх сэтгэлийн зовлонг, мөн түүнчлэн хаандаа хандсан хүмүүсийн бүх гомдлуудыг хаан Мозая тэдэнд бичив; мөн тэр энэ бүгдийг тэдэнд тайлбарлав.

34 Мөн эдгээр зүйлүүд байх нь зохистой бус; харин хүн бүр өөрийн хувийг үүрч болохын тулд ачаа нь бүх хүмүүсийн дээр ирвэл зохихыг тэрээр тэдэнд ярив.

35 Мөн түүнчлэн тэрээр зөв шударга биш хаан тэдний дээр хаанчилж байхад, тэдний харах бүх дутагдалтай талуудыг тэдэнд дэлгэн үзүүлэв.

36 Тийм ээ, түүний бүх алдсууд хийгээд жигшүүрт хэргүүд, мөн бүх дайнууд, мөн тэмцлүүд, мөн цус урсалт, бас хулгай, мөн дээрэм, түүнчлэн садар самууныг үйлдэх, мөн тоолж нэрлэгдэх боломжгүй бүх төрлийн алдсууд—тэдгээр нь Бурханы зарлигуудад илт харш учир тэдгээр зүйлүүд байх ёсгүйг тэдэнд хэлж өгөв.

37 Мөн эдүгээ улиран тохиох дор, хаан Мозая эдгээр зүйлийг хүмүүсийн дунд илгээсний дараа тэд түүний үгсийн үнэнд үнэмшив.

38 Тиймийн тул тэд хаантай байх хүслээсээ татгалзаж, мөн бүх нутаг даяар хүн бүр адил тэгш эрхтэй байхад үлэмж догдолж байв; тийм ээ, мөн хүн бүр нүглүүдээ хариуцахад бэлэн буйгаа илэрхийлэв.

39 Тиймийн тул, улиран тохиох дор тэдэнд өгөгдсөн хуулийн дагуу тэднийг шүүх шүүгчид хэн байх талаар саналаа өгөхөөр тэд нутаг даяар хэсгүүдэд нэгдэн цуглаарав; мөн тэд өөрсдөд нь соёрхогдсон эрх чөлөөний учир үлэмж баясав.

And many more things did king Mosiah write unto them, unfolding unto them all the trials and troubles of a righteous king, yea, all the travails of soul for their people, and also all the murmurings of the people to their king; and he explained it all unto them.

And he told them that these things ought not to be; but that the burden should come upon all the people, that every man might bear his part.

And he also unfolded unto them all the disadvantages they labored under, by having an unrighteous king to rule over them;

Yea, all his iniquities and abominations, and all the wars, and contentions, and bloodshed, and the stealing, and the plundering, and the committing of whoredoms, and all manner of iniquities which cannot be enumerated—telling them that these things ought not to be, that they were expressly repugnant to the commandments of God.

And now it came to pass, after king Mosiah had sent these things forth among the people they were convinced of the truth of his words.

Therefore they relinquished their desires for a king, and became exceedingly anxious that every man should have an equal chance throughout all the land; yea, and every man expressed a willingness to answer for his own sins.

Therefore, it came to pass that they assembled themselves together in bodies throughout the land, to cast in their voices concerning who should be their judges, to judge them according to the law which had been given them; and they were exceedingly rejoiced because of the liberty which had been granted unto them.

40 Мөн Мозаяд хандсан тэдний хайр нь хүчтэй болсон ажгуу; тийм ээ, өөр бусад ямар ч хүнээс илүү хүндэлсэн аж; учир нь хөрөнгийг, тийм ээ, сүнсийг ялзраах тэрхүү эд баялгийг эрэлхийлэгч дарлагчийн адил тэд түүнийг эс үзжээ; учир нь тэрээр баялгийг тэднээс шаардсангүй, бас цус урсахад ч баяссан нь үгүй; харин уг нутагт амар амгаланг тэр тогтоож, мөн тэд бүх төрлийн боолчлолоос чөлөөлөгдөх нь шаардлагатайг тэрээр хүмүүстээ зөвшөөрчээ; тиймийн тул тэд түүнийг, тийм ээ, үлэмж, хэмжээлшгүй ихээр хүндэтгэж.

41 Мөнхүү улиран тохиох дор тэдний дээр захирах, эсвээс тэднийг хуулийн дагуу шүүх шүүгчдийг тэд томилсон болой; мөн тэд үүнийг бүх нутаг даяар хийв.

42 Мөнхүү улиран тохиох дор Алма тэргүүн ерөнхий шүүгч байхаар томилогдов, мөн тэрээр түүнчлэн дээд санваартан байсан учир, эцэг нь түүний дээр алба тохоов, мөн сүмийн бүх хэргүүдийн талаарх хариуцлагыг түүнд өгсний учир бөлгөө.

43 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма Их Эзэний замуудаар алхаж, мөн тэрээр түүний зарлигуудыг дагаж, мөн зөв шударга шүүлтүүдээр тэр шүүсэн болой; мөн уг нутаг даяар үргэлжийн амгалан байв.

44 Мөн тийн Зарахемлагийн бүх нутаг даяар, нифайчууд гэж нэрлэгдсэн бүх хүмүүсийн дунд шүүгчдийн засаглал эхлэв; мөн Алма тэргүүн мөн ерөнхий шүүгч байв.

45 Мөн эдүгээ улиран тохиох дор наян хоёр настай байхдаа, мөн Бурханы зарлигуудыг гүйцэлдүүлэхээр амьдарч асан түүний эцэг насан эцэслэв.

46 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн Мозая засаглалынхаа гучин гурав дахь жилд, жаран гурван настайдаа насан эцэслэв; мөн тэгэхээр Лихай Иерусалимыг орхисон цагаас хойш нийтдээ таван зуун есөн жил болжээ.

47 Мөн Нифайн хүмүүсийн дээрх хаадын засаглалын төгсөв; мөн тэдний сүмийг үндэслэгч асан, Алмагийн өдрүүд тийн төгсөв.

And they did wax strong in love towards Mosiah; yea, they did esteem him more than any other man; for they did not look upon him as a tyrant who was seeking for gain, yea, for that lucre which doth corrupt the soul; for he had not exacted riches of them, neither had he delighted in the shedding of blood; but he had established peace in the land, and he had granted unto his people that they should be delivered from all manner of bondage; therefore they did esteem him, yea, exceedingly, beyond measure.

And it came to pass that they did appoint judges to rule over them, or to judge them according to the law; and this they did throughout all the land.

And it came to pass that Alma was appointed to be the first chief judge, he being also the high priest, his father having conferred the office upon him, and having given him the charge concerning all the affairs of the church.

And now it came to pass that Alma did walk in the ways of the Lord, and he did keep his commandments, and he did judge righteous judgments; and there was continual peace through the land.

And thus commenced the reign of the judges throughout all the land of Zarahemla, among all the people who were called the Nephites; and Alma was the first and chief judge.

And now it came to pass that his father died, being eighty and two years old, having lived to fulfil the commandments of God.

And it came to pass that Mosiah died also, in the thirty and third year of his reign, being sixty and three years old; making in the whole, five hundred and nine years from the time Lehi left Jerusalem.

And thus ended the reign of the kings over the people of Nephi; and thus ended the days of Alma, who was the founder of their church.

# АЛМАГИЙН НОМАЛМАГИЙН ХҮҮ АСАН

*Алмагийн хүү асан, Нифайн хүмүүсийн дээрх тэргүүн мөн ерөнхий шүүгч, мөн түүнчлэн Сүмийн дээрх дээд санваартан асан, Алмагийн шастир оршвой. Шүүгчдийн засаглал, мөн хүмүүсийн хоорондох дайнүүд хийгээд зөрчлүүдийн талаарх шастир оршвой. Мөн түүнчлэн тэргүүн мөн ерөнхий шүүгч Алмагийн цэдгийн дагуу нифайчууд хийгээд леменчүүдийн дундах дайны шастир оршвой.*

## Алма 1

- 1 ЭДҮГЭЭ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын эхний жил, хаан Мозая амьдралыг зөвөөр залж, Бурханы өмнө зөв шударгаар алхлан, өөрийн оронд засаглах хэнийг ч үлдээлгүйгээр бүх хорвоогийн жамаар одов; гэсэн хэдий ч тэрээр хуулиудыг тогтоож, тэдгээр нь хүмүүсээр хүлээн зөвшөөрөгдсөн байв; тиймийн тул, энэ цагаас эхлэн, тэд түүний тогтоосон хуулиудаар амьдрахаар албадуулсан байв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Алмагийн шүүлтийн суудал дахь засаглалын эхний жилд, нэгэн хүн шүүгдэхээр түүний өмнө авчрагдсан нь, том биетэй, их хүчтэйгээрээ нэрд гарсан нэгэн бөлгөө.
- 3 Мөн тэрээр хүмүүсийн дунд явж, тэрээр Бурханы үг хэмээн нэрлэсэн зүйлээ тэдэнд номлон, сүмийн эсрэг тэмцэв; санваартан мөн багш бүр нэр хүндтэй болохыг; мөн тэд өөрсдийн гараар хөдөлмөрлөхгүй байвал зохихыг, харин тэд хүмүүсээр тэтгэгдэх ёстойг хүмүүст тунхагладаг байв.
- 4 Мөн эцсийн өдөр бүх хүн төрөлхтөн аврагдах болно, мөн тэд айх бас чичрэх ч хэрэггүй, харин тэд тэргүүнээ өргөн мөн баясаж болох ажээ; учир нь Их Эзэн бүх хүмүүнийг бүтээсэн, мөн түүнчлэн бүх хүмүүнийг гэтэлгэсэн; мөн, төгсгөлд нь, бүх хүмүүн мөнх амьдралтай байна хэмээн тэрээр хүмүүст түүнчлэн гэрчлэв.

# The Book of Alma

*The account of Alma, who was the son of Alma, the first and chief judge over the people of Nephi, and also the high priest over the Church. An account of the reign of the judges, and the wars and contentions among the people. And also an account of a war between the Nephites and the Lamanites, according to the record of Alma, the first and chief judge.*

## Alma 1

Now it came to pass that in the first year of the reign of the judges over the people of Nephi, from this time forward, king Mosiah having gone the way of all the earth, having warred a good warfare, walking uprightly before God, leaving none to reign in his stead; nevertheless he had established laws, and they were acknowledged by the people; therefore they were obliged to abide by the laws which he had made.

And it came to pass that in the first year of the reign of Alma in the judgment-seat, there was a man brought before him to be judged, a man who was large, and was noted for his much strength.

And he had gone about among the people, preaching to them that which he termed to be the word of God, bearing down against the church; declaring unto the people that every priest and teacher ought to become popular; and they ought not to labor with their hands, but that they ought to be supported by the people.

And he also testified unto the people that all mankind should be saved at the last day, and that they need not fear nor tremble, but that they might lift up their heads and rejoice; for the Lord had created all men, and had also redeemed all men; and, in the end, all men should have eternal life.



- 5 Мөнхүү улиран тохиох дор олон нь түүний үгсэд итгэхээр тийм ихээр тэр эдгээр зүйлийг заасан аж, бүр тэд түүнийг дэмжиж мөн түүнд мөнгө өгч эхэлсэн нь тийм олон байсан бөлгөө.
- 6 Мөн тэрээр зүрхнийхээ бардамналд хөөрч эхлэв, мөн маш үнэтэй хувцас хунар өмсөж, тийм ээ, мөн өөрийн номлолын дагуу бүр сүм байгуулж эхэлсэн билээ.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэр өөрийнх нь үгэнд итгэсэн тэдэнд номлохоор явж байхдаа, тэр Бурханы сүмд хамаарагдах нэгэн хүнтэй, тийм ээ, бүр тэдний багш нарын нэгтэй нь тааралдав; мөн сүмийн хүмүүсийг тэрбээр зайцуулан удирдаж болохын тулд тэр түүнтэй хурцаар маргалдаж эхлэв; гэвч уг хүн Бурханы үгсээр түүнийг зэмлэн түүнийг эсэргүүцэв.
- 8 Эдүгээ сайхь хүний нэр Гидеон байв; мөн Лимхайн хүмүүсийг дарангуйллаас чөлөөлөхөд Бурханы мутарт зэмсэг байсан тэр байв.
- 9 Эдүгээ, Бурханы үгсээр Гидеон түүнийг сөрөн зогссон учир тэр Гидеонд хилэгнэж, мөн илдээ сугалаад түүнийг дайрч эхлэв. Эдүгээ Гидеон олон жил насалсан байв, тиймийн тул тэрээр түүний дайралтуудыг эсэргүүцэн зогсох чадалгүй байлаа, тиймийн тул тэрээр илдэнд хөнөөгдөв.
- 10 Мөн түүнийг хөнөөсөн хүн сүмийн хүмүүсээр баривчлагдаж, мөн тэр үйлдсэн гэмт хэргүүдийнхээ дагуу шүүгдэхээр Алмагийн өмнө авчрагдав.
- 11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Алмагийн өмнө зогсож мөн ихэд зоригтойгоор өөрийгөө өмгөөлөв.
- 12 Харин Алма түүнд хэлэв: Болгоогтун, санваараар мэргэших нь хүмүүсийн дунд анх удаа танилцуулагдсан нь энэ юм. Мөн болгоогтун, та зөвхөн санваараар мэргэшсэний ч гэмтэй биш, бас үүнийг илдээр албадахыг оролдсон байна; мөн санваараар мэргэших нь энэ хүмүүсийн дунд албаар тулгагдваас энэ нь тэдний бүрэн устгалын шалтгаан болох сон.
- 13 Мөн та зөв шударга хүний цусыг, тийм ээ, энэ хүмүүсийн дунд ихээхэн сайныг хийсэн тэр хүнийхийг урсгалаа; мөн бид таныг хэлтрүүлэх аваас түүний цус өшөө хонзонгийн учир бидэн дээр ирэх болно.

And it came to pass that he did teach these things so much that many did believe on his words, even so many that they began to support him and give him money.

And he began to be lifted up in the pride of his heart, and to wear very costly apparel, yea, and even began to establish a church after the manner of his preaching.

And it came to pass as he was going, to preach to those who believed on his word, he met a man who belonged to the church of God, yea, even one of their teachers; and he began to contend with him sharply, that he might lead away the people of the church; but the man withstood him, admonishing him with the words of God.

Now the name of the man was Gideon; and it was he who was an instrument in the hands of God in delivering the people of Limhi out of bondage.

Now, because Gideon withstood him with the words of God he was wroth with Gideon, and drew his sword and began to smite him. Now Gideon being stricken with many years, therefore he was not able to withstand his blows, therefore he was slain by the sword.

And the man who slew him was taken by the people of the church, and was brought before Alma, to be judged according to the crimes which he had committed.

And it came to pass that he stood before Alma and pled for himself with much boldness.

But Alma said unto him: Behold, this is the first time that priestcraft has been introduced among this people. And behold, thou art not only guilty of priestcraft, but hast endeavored to enforce it by the sword; and were priestcraft to be enforced among this people it would prove their entire destruction.

And thou hast shed the blood of a righteous man, yea, a man who has done much good among this people; and were we to spare thee his blood would come upon us for vengeance.

- 14 Тиймийн тул та, бидний сүүлчийн хаан,  
Мозаягаар бидэнд өгөгдсөн тэр хуулийн дагуу үхэ-  
хээр яллагдлаа; мөн энэ нь хүмүүсээр хүлээн зөв-  
шөөрөгдсөн бөлгөө; тиймийн тул энэ хүмүүс уг хуу-  
лийг мөрдөх ёстой.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг баривч-  
лав; мөн түүний нэр Нихор байв; мөн тэд түүнийг  
Мантай толгойн орой дээр аваачиж, тэнгэр газрын  
савслаганд хүмүүст түүний заасан нь Бурханы үгний  
эсрэг байсан гэдгээ тэрээр хүлээн зөвшөөрөв, эсвээс  
өөрөөр хэлбэл, мөн тэнд тэр албадуулагдав; мөн  
тэнд тэрээр ичгүүрт үхлийг үзэв.
- 16 Гэсэн хэдий ч, энэ нь санваараар мэргэшихийг уг  
нутаг даяар тархахыг төгсгөл болгосонгүй; учир нь  
дэлхийн хоосон чанарын зүйлүүдэд дуртай болсон  
нь олон байв, мөн тэд хуурамч сургаалуудыг номлон  
явж байв; мөн тэд үүнийг баялаг болоод алдрын тө-  
лөө хийсэн бөлгөө.
- 17 Гэсэн хэдий ч, тэд мэдэгдэхээр худал хэлж зүрхэл-  
сэнгүй, худалчид шийтгэгдэж байсан тул хуулийн  
учир айсан аж; тиймийн тул тэд сүсэг бишрэлийнхээ  
дагуу номлож буй дүр үзүүлж байв; мөн эдүгээ уг  
хууль нь сүсэг бишрэлийн хувьд ямар ч хүний дээр  
хүчгүй байв.
- 18 Мөн тэд хуулиас айх учир хулгайлж зүрхэлсэнгүй,  
тийм нь шийтгэгдэж байсны учир бөлгөө; бас тэд  
дээрэм, мөн аллага хийж зүрхэлсэнгүй, учир нь ал-  
лага хийсэн нь үхлээр шийтгэгдэж байлаа.
- 19 Гэвч улиран тохиох дор Бурханы сүмд хамаараг-  
даагүй хэн боловч Бурханы сүмд харьяалагдаж,  
Христийн нэрийг өөрсдийн дээр авсан тэднийг хав-  
чин гадуурхаж эхлэв.
- 20 Тийм ээ, тэд тэднийг хавчин гадуурхаж, мөн тэд-  
нийг янз бүрийн үгсээр зовоож байв, мөн энэ нь тэд-  
ний даруу төлвийн учир бөлгөө; учир нь тэд өөрс-  
дийн нүдэнд бардам байсангүй, мөн тэд Бурханы  
үгийг нэг нэгэнтэйгээ, мөнгөгүйгээр мөн үнэгүйгээр  
хуваалцдаг байсны учир бөлгөө.
- 21 Эдүгээ сүмийн хүмүүсийн дунд, сүмд харьяалагд-  
сан нэг ч хүн сүмд харьяалагдаагүй тэдний эсрэг босч  
мөн хавчин гадуурхаж болохгүй, мөн тэдний өөрс-  
дийнх нь дунд ч хавчлага байх ёсгүй хэмээх хатуу  
хууль байв.

Therefore thou art condemned to die, according to  
the law which has been given us by Mosiah, our last  
king; and it has been acknowledged by this people;  
therefore this people must abide by the law.

And it came to pass that they took him; and his name  
was Nehor; and they carried him upon the top of the  
hill Manti, and there he was caused, or rather did ac-  
knowledge, between the heavens and the earth, that  
what he had taught to the people was contrary to the  
word of God; and there he suffered an ignominious  
death.

Nevertheless, this did not put an end to the spread-  
ing of priestcraft through the land; for there were many  
who loved the vain things of the world, and they went  
forth preaching false doctrines; and this they did for the  
sake of riches and honor.

Nevertheless, they durst not lie, if it were known, for  
fear of the law, for liars were punished; therefore they  
pretended to preach according to their belief; and now  
the law could have no power on any man for his belief.

And they durst not steal, for fear of the law, for such  
were punished; neither durst they rob, nor murder, for  
he that murdered was punished unto death.

But it came to pass that whosoever did not belong to  
the church of God began to persecute those that did be-  
long to the church of God, and had taken upon them  
the name of Christ.

Yea, they did persecute them, and afflict them with  
all manner of words, and this because of their humility;  
because they were not proud in their own eyes, and be-  
cause they did impart the word of God, one with an-  
other, without money and without price.

Now there was a strict law among the people of the  
church, that there should not any man, belonging to  
the church, arise and persecute those that did not be-  
long to the church, and that there should be no persecu-  
tion among themselves.

- 22 Гэсэн хэдий ч, тэдний дунд бардам болж эхэлсэн нь, мөн өрсөлдөгчидтэйгээ ширүүн, бүр зодолдох хүртлээ тэмцэлдэж эхэлсэн нь олон байв; тийм ээ, тэд бие биенээ нударгалан жанчих болов.
- 23 Эдүгээ энэ нь Алмагийн засаглалын хоёр дахь жилд, мөн энэ нь сүмд их зүдгүүрийн шалтгаан байв; тийм ээ, энэ нь сүмд их бэрхшээлийн шалтгаан байв.
- 24 Учир нь олны зүрх сэтгэл хатуурч, мөн Бурханы хүмүүсийн дунд тэд дахин дурсагдахгүйн тулд тэдний нэрс арилгагдав. Мөн түүнчлэн олон нь тэдний дундаас өөрсдийгөө холдуулав.
- 25 Эдүгээ энэ нь сүсэг бишрэлдээ үнэнч үлдсэн тэдэнд агуу бэрхшээл болов; гэсэн хэдий ч, тэд Бурханы зарлигуудыг дагахдаа хөдөлшгүй мөн гуйвшгүй байв, мөн тэд өөрсдийн дээр овоологдсон хавчлага гадуурхлыг тэвчээртэйгээр үүрч байв.
- 26 Мөн санваартнууд Бурханы үгийг хүмүүстэй хуваалцахаар хөдөлмөрөө орхиход, хүмүүс ч түүнчлэн Бурханы үгийг сонсохоор хөдөлмөрлөхөө орхиж байв. Мөн санваартан тэдэнд Бурханы үгийг дуулгамагц тэд бүгд хөдөлмөртөө дахин хичээнгүйлэн орж байв; мөн санваартан нь, өөрийгөө сонсогчдоосоо дээр хэмээн үнэлэхээ больсон аж, учир нь номлогч нь сонсогчоосоо өчүүхэн ч илүү бус ажгуу, бас багш нь сурагчаасаа илүү бус бөлгөө; мөн тийн тэд бүгд адил тэгш, мөн тэд бүгд, хүн бүр өөрт буй хүчнийхээ дагуу хөдөлмөрлөж байв.
- 27 Мөн тэд хөрөнгөнөөсөө, хүн бүр өөрт байгаагийнхаа хэрээр, ядуутай, мөн гачигдсантай, мөн өвдсөнтэй мөн зовж зүдэрсэнтэй хуваалцаж байлаа; мөн тэд үнэтэй хувцас хунар өмсдөггүй байв, гэвч тэд цэвэр нямбай мөн дур булаам байсан буюу.
- 28 Мөн тийн тэд сүмийн хэргүүдийг тогтоов; мөн тийн тэдний бүх хавчлагууд байсан хэдий ч тэд үргэлжийн амгаланг дахин эдэлж эхлэв.
- 29 Мөн эдүгээ, сүмийн чанд байдлын учир тэд үлэмж баян болж эхлэн, тэдэнд хэрэгцээтэй аливаа бүх зүйлээр—үй түмэн бог мөн бод мал, мөн зүйл бүрийн төл мал, мөн түүнчлэн арвин их үр тариа, мөн алт, мөн мөнгө, мөн үнэт зүйлүүд, мөн арвин их торго хийгээд нарийн нэхээст эд, мөн төрөл бүрийн энгийн сайн даавуугаар элбэг хангалуун байх болов.

Nevertheless, there were many among them who began to be proud, and began to contend warmly with their adversaries, even unto blows; yea, they would smite one another with their fists.

Now this was in the second year of the reign of Alma, and it was a cause of much affliction to the church; yea, it was the cause of much trial with the church.

For the hearts of many were hardened, and their names were blotted out, that they were remembered no more among the people of God. And also many withdrew themselves from among them.

Now this was a great trial to those that did stand fast in the faith; nevertheless, they were steadfast and immovable in keeping the commandments of God, and they bore with patience the persecution which was heaped upon them.

And when the priests left their labor to impart the word of God unto the people, the people also left their labors to hear the word of God. And when the priest had imparted unto them the word of God they all returned again diligently unto their labors; and the priest, not esteeming himself above his hearers, for the preacher was no better than the hearer, neither was the teacher any better than the learner; and thus they were all equal, and they did all labor, every man according to his strength.

And they did impart of their substance, every man according to that which he had, to the poor, and the needy, and the sick, and the afflicted; and they did not wear costly apparel, yet they were neat and comely.

And thus they did establish the affairs of the church; and thus they began to have continual peace again, notwithstanding all their persecutions.

And now, because of the steadiness of the church they began to be exceedingly rich, having abundance of all things whatsoever they stood in need—an abundance of flocks and herds, and fatlings of every kind, and also abundance of grain, and of gold, and of silver, and of precious things, and abundance of silk and fine-twined linen, and all manner of good homely cloth.

30 Мөн тийн, тэд нүцгэрсэн, эсвэл өлссөн, эсвэл цангасан, эсвэл өвдсөн, эсвэл асаргаагүй байсан нэгнийг ч хангалуун байдалдаа тэд буцаагаагүй болой; мөн тэд зүрх сэтгэлээ баялаг дээр тулгуурласангүй; тиймийн тул тэд, настай мөн залуу аль алинд нь, боол мөн чөлөөт аль алинд нь, эрэгтэй мөн эмэгтэй аль алинд нь, сүмийнх биш ч бай, мөн ч бай, чухам ямар хүмүүс байгаагаас нь үл хамааран гачигдах тэднийг бүгдийг энэрч байв.

31 Мөн тийн тэд дэгжиж мөн сүмд нь харьяалагдаагүй тэднээс хамаагүй илүү чинээлэг болов.

32 Учир нь тэдний сүмд харьяалагдаагүй тэд илбэ шидэд, мөн хиймэл шүтээнийг шүтэхэд эсвээс залхуу хойрго байдалд, мөн чалчаа яриа, мөн атаа жөтөө мөн хэрүүл маргаанд өөрсдийгөө өөгшүүлж байв; үнэтэй хувцас өмсөн; өөрсдийнхөө нүдэнд бардамнан хөөрч; бусдыг хавчин, худал хэлж, хулгайлж, дээрэмдэж, садар самууныг үйлдэн, мөн аллага, мөн зүйл бүрийн ёс бусыг үйлдэж байв; гэсэн хэдий ч, үүнийг зөрчсөн тэд бүгдийн дээр уг хууль боломжийн хэрээр хэрэгжүүлэгдэж байв.

33 Мөнхүү улиран тохиох дор хүн бүр өөрийн хийсэн зүйлийхээ дагуу шийтгэгдэн, тэдний дээр хуулийг хэрэгжүүлснээр, тэд илүү тайван болж, мөн хэрэв мэдэгдэхээр бол ямар ч ёс бусыг үйлдэж зүрхлэхгүй байв; тиймийн тул, Нифайн хүмүүсийн дунд шүүгчдийн засаглалын тав дахь жилийг хүртэл туйлын их амар амгалан байв.

And thus, in their prosperous circumstances, they did not send away any who were naked, or that were hungry, or that were athirst, or that were sick, or that had not been nourished; and they did not set their hearts upon riches; therefore they were liberal to all, both old and young, both bond and free, both male and female, whether out of the church or in the church, having no respect to persons as to those who stood in need.

And thus they did prosper and become far more wealthy than those who did not belong to their church.

For those who did not belong to their church did indulge themselves in sorceries, and in idolatry or idleness, and in babblings, and in envyings and strife; wearing costly apparel; being lifted up in the pride of their own eyes; persecuting, lying, thieving, robbing, committing whoredoms, and murdering, and all manner of wickedness; nevertheless, the law was put in force upon all those who did transgress it, inasmuch as it was possible.

And it came to pass that by thus exercising the law upon them, every man suffering according to that which he had done, they became more still, and durst not commit any wickedness if it were known; therefore, there was much peace among the people of Nephi until the fifth year of the reign of the judges.

## Алма 2

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэдний засаглалын тав дахь жилийн эхэнд хүмүүсийн дунд нэгэн зөрчилдөөн гарч эхлэв; учир нь, Амлисай гэж нэрлэгдсэн нэгэн хүн, тэрээр машид зальжин эр байж, тийм ээ, энэ дэлхийн мэргэн ухааны хувьд ухаалаг хүн буюу, тэр Гидеоныг илдээр алж, хуульд заасны дагуу цаазлагдсан хүний жаягийн дагуу байв—
- 2 Эдүгээ сайхь Амлисай заль мэхээрээ тийм олон хүнийг, бүр тэд ихэд хүчтэй болж эхэлсэн; олон хүнийг өөрийн араас дагуулав; мөн тэд Амлисайг уг хүмүүсийг захирах хаан болгохыг оролдож эхлэв.
- 3 Эдүгээ энэ нь сүмийн хүмүүсийг, мөн түүнчлэн Амлисайн ятгалганд автаагүй тэдгээр бүх хүмүүсийг цочирдуулав; учир нь ийм зүйлүүд тэдний хуулийн дагуу хүмүүсийн саналаар тогтоогдох ёстойг тэд мэдэж байв.
- 4 Тиймийн тул, хэрэв Амлисай хүмүүсийн саналыг авах нь боломжтой байсан бол, тэрээр, ёс бус хүмүүн байсан учир, сүмийнх нь эрх хийгээд боломжуудыг тэднээс булааж авах буйза; учир нь Бурханы сүмийг устгах нь түүний санаа байв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс бүх нутаг даяар, Амлисайг дэмжсэн эсэргүүцсэн алин боловч хүн бүр өөрийн бодлын дагуу тус тусдаа цуглан чуулж, мөн тэд нэг нэгэнтэйгээ ширүүн маргаан болон их зөрчилдөөнтэй байв.
- 6 Мөн тийн уг хэргийн талаар саналаа өгөхөөр тэд өөрсдөө нэгдэн цугларцгаав; мөн тэдгээр нь шүүгчдийн өмнө толилуулагдав.
- 7 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал Амлисайн эсрэг ирсэн учир тэрээр хүмүүсийн дээрх хаанаар тохоогдсонгүй.
- 8 Эдүгээ энэ нь түүний эсрэг байсан тэдний зүрх сэтгэлд маш их баяр хөөр авчрав; харин Амлисай өөрийнх нь талд байсан тэднийг түүний талд байгаагүй тэдний эсрэг уурлуулахаар өдөөн хатгав.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдөө цугларцгааж, мөн Амлисайг хаанаа болгохоор томилон адислав.

## Alma 2

And it came to pass in the commencement of the fifth year of their reign there began to be a contention among the people; for a certain man, being called Amlici, he being a very cunning man, yea, a wise man as to the wisdom of the world, he being after the order of the man that slew Gideon by the sword, who was executed according to the law—

Now this Amlici had, by his cunning, drawn away much people after him; even so much that they began to be very powerful; and they began to endeavor to establish Amlici to be a king over the people.

Now this was alarming to the people of the church, and also to all those who had not been drawn away after the persuasions of Amlici; for they knew that according to their law that such things must be established by the voice of the people.

Therefore, if it were possible that Amlici should gain the voice of the people, he, being a wicked man, would deprive them of their rights and privileges of the church; for it was his intent to destroy the church of God.

And it came to pass that the people assembled themselves together throughout all the land, every man according to his mind, whether it were for or against Amlici, in separate bodies, having much dispute and wonderful contentions one with another.

And thus they did assemble themselves together to cast in their voices concerning the matter; and they were laid before the judges.

And it came to pass that the voice of the people came against Amlici, that he was not made king over the people.

Now this did cause much joy in the hearts of those who were against him; but Amlici did stir up those who were in his favor to anger against those who were not in his favor.

And it came to pass that they gathered themselves together, and did consecrate Amlici to be their king.

- 10 Эдүгээ Амлисай тэдний дээрх хаанаар тохоогд-  
могцоо тэрээр тэднийг ах дүүсийнхээ эсрэг зэвсгээ  
агсахыг тэдэнд зарлиглав; мөн тэрээр тэднийг өөр-  
төө харьяалуулж болохын тулд үүнийг хийсэн бо-  
лой.
- 11 Эдүгээ Амлисайн хүмүүс амлисайчууд гэж нэр-  
лэгдэн, Амлисайн нэрээр ялгагдах болов; мөн үлд-  
сэн нь нифайчууд буюу Бурханы хүмүүс хэмээн нэр-  
лэгдэж асан бөлгөө.
- 12 Тиймийн тул Нифайн хүмүүс амлисайчуудын зо-  
рилтын талаар мэдэж байв, мөн тиймийн тул тэдэн-  
тэй тулгарахаар тэд бэлтгэл хийв; тийм ээ, тэд өөрс-  
дийгөө сэлэм, мөн илд, мөн нум, мөн сум, мөн чу-  
луу, мөн дүүгүүр, мөн зүйл бүрийн дайны зэвсгээр,  
төрөл бүрээр нь зэвсэглэв.
- 13 Мөн тэднийг ирэх үед нь амлисайчуудтай тулгара-  
хаар тэд тийн бэлтгэсэн байв. Мөн ахлагчид, мөн  
дээд ахлагчид, мөн ерөнхий ахлагчид зохих тоогоо-  
роо томилогдсон байв.
- 14 Мөнхүү улиран тохиох дор Амлисай өөрийн эр-  
чүүдийг олон зүйлийн төрөл бүрийн дайны зэвсгээр  
зэвсэглэв; мөн хүмүүсийнхээ дээр тэднийг ах дүү-  
сийнх нь эсрэг дайнд удирдах захирагч мөн толгой-  
логчдыг тэр түүнчлэн томилов.
- 15 Мөнхүү улиран тохиох дор амлисайчууд  
Зарахемла нутгийн дэргэдүүр урсдаг, Сидон голын  
дорнод тэр Амнайхү толгой дээр ирж, мөн тэнд тэд  
нифайчуудтай дайтаж эхлэв.
- 16 Эдүгээ Алма, Нифайн хүмүүсийн ерөнхий шүүгч  
мөн засаглагч байв, тиймийн тул тэрээр өөрийн хү-  
мүүстэй, тийм ээ, ахлагч нартайгаа, мөн ерөнхий ах-  
лагч нартайгаа, тийм ээ, амлисайчуудын эсрэг дайт-  
ахаар их цэргийнхээ тэргүүнд явав.
- 17 Мөн тэд Сидоны зүүн талын толгой дээр амли-  
сайчуудыг хөнөөж эхлэв. Мөн амлисайчууд агуу хү-  
чээр нифайчуудтай тэмцэж, үүний хэрээр нифайчуу-  
дын олон нь амлисайчуудын өмнө унасан болой.
- 18 Гэсэн хэдий ч нифайчуудын гарыг Их Эзэн хүчир-  
хэгжүүлснээр тэд их хөнөөлөөр амлисайчуудыг хө-  
нөөж, тэдний өмнө тэд зугтаж эхэлсэн болой.

Now when Amlici was made king over them he com-  
manded them that they should take up arms against  
their brethren; and this he did that he might subject  
them to him.

Now the people of Amlici were distinguished by the  
name of Amlici, being called Amlicites; and the remain-  
der were called Nephites, or the people of God.

Therefore the people of the Nephites were aware of  
the intent of the Amlicites, and therefore they did pre-  
pare to meet them; yea, they did arm themselves with  
swords, and with cimeters, and with bows, and with ar-  
rows, and with stones, and with slings, and with all  
manner of weapons of war, of every kind.

And thus they were prepared to meet the Amlicites  
at the time of their coming. And there were appointed  
captains, and higher captains, and chief captains, ac-  
cording to their numbers.

And it came to pass that Amlici did arm his men with  
all manner of weapons of war of every kind; and he also  
appointed rulers and leaders over his people, to lead  
them to war against their brethren.

And it came to pass that the Amlicites came upon the  
hill Amnihu, which was east of the river Sidon, which  
ran by the land of Zarahemla, and there they began to  
make war with the Nephites.

Now Alma, being the chief judge and the governor  
of the people of Nephi, therefore he went up with his  
people, yea, with his captains, and chief captains, yea, at  
the head of his armies, against the Amlicites to battle.

And they began to slay the Amlicites upon the hill  
east of Sidon. And the Amlicites did contend with the  
Nephites with great strength, insomuch that many of  
the Nephites did fall before the Amlicites.

Nevertheless the Lord did strengthen the hand of the  
Nephites, that they slew the Amlicites with great  
slaughter, that they began to flee before them.

19 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд бүхэл өдөр амлисайчуудыг мөшгөн, мөн их хөнөөлөөр тэднийг хөнөөв, үүний хэрээр амлисайчуудаас арван хоёр мянга таван зуун гучин хоёр бодгаль алагдав; мөн нифайчуудын зургаан мянга таван зуун жаран хоёр бодгаль алагдсан байв.

20 Мөнхүү улиран тохиох дор амлисайчуудыг дахин цааш мөшгөх боломжгүй болоод Алма өөрийн хүмүүсийг Нихорын гараар илдэнд алагдсан Гидеоны нэрээр нэрлэгдсэн нэгэн хөндий, Гидеоны хөндийд майхнуудаа босгохоор болгов; мөн энэ хөндийд нифайчууд шөнө хоноглохоор майхнуудаа босгосон ажээ.

21 Мөн тэгснээр өөрийгөө тэднээс хамгаалж болохын тулд, өөрийн хүмүүсийг устгагдахаас хамгаалан үлдэж болохын тулд, тэдний төлөвлөгөөнүүд хийгээд тэдний санааг мэдэхийн тулд амлисайчуудын үлдэгдлийг дагах туршуулуудыг Алма илгээв.

22 Эдүгээ амлисайчуудын буудлыг ажиглахаар түүний гадагш илгээсэн тэднийг Зерам, Амнор, Мантай, Лимхер гэж нэрлэдэг байв; эдгээр нь амлисайчуудын буудлыг харахаар эрчүүдтэйгээ явсан тэд байв.

23 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь тэд ихэд гайхан цочирдон, мөн үлэмж айснаас балмагдан, нифайчуудын буудалд ихэд яаравчлан тэд эргэж ирээд, хэлрүүн:

24 Болгоогтун, бид амлисайчуудын буудлыг дагалаа, мөн бидний гайхлыг ихэд төрүүлсэн нь юув гэвэл, Зарахемла нутгийн дээрх Минон нутагт, Нифайн нутагт очих замд, бид леменчүүдийн олон тооны их цэргийг харлаа; мөн болгоогтун, амлисайчууд тэдэнтэй нэгдсэн бөлгөө;

25 Мөн тэд уг нутаг дахь ах дүүсийн маань дээр байна, мөн тэд мал сүрэг, мөн эхнэр, мөн хүүхдүүдтэйгээ манай хотын зүг тэдний өмнө зугтаж явна; мөн хэрэв бид яарахгүй аваас тэд хотыг маань эзэмшилдээ авч, мөн бидний эцэг, мөн эхнэрүүд маань, мөн хүүхдүүд маань алагдах болно.

26 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүс майхнуудаа авч, мөн Гидеоны хөндийгөөс гарч Зарахемлагийн хот болох тэр хотынхоо зүг одов.

And it came to pass that the Nephites did pursue the Amlicites all that day, and did slay them with much slaughter, insomuch that there were slain of the Amlicites twelve thousand five hundred thirty and two souls; and there were slain of the Nephites six thousand five hundred sixty and two souls.

And it came to pass that when Alma could pursue the Amlicites no longer he caused that his people should pitch their tents in the valley of Gideon, the valley being called after that Gideon who was slain by the hand of Nehor with the sword; and in this valley the Nephites did pitch their tents for the night.

And Alma sent spies to follow the remnant of the Amlicites, that he might know of their plans and their plots, whereby he might guard himself against them, that he might preserve his people from being destroyed.

Now those whom he had sent out to watch the camp of the Amlicites were called Zeram, and Amnor, and Manti, and Limher; these were they who went out with their men to watch the camp of the Amlicites.

And it came to pass that on the morrow they returned into the camp of the Nephites in great haste, being greatly astonished, and struck with much fear, saying:

Behold, we followed the camp of the Amlicites, and to our great astonishment, in the land of Minon, above the land of Zarahemla, in the course of the land of Nephi, we saw a numerous host of the Lamanites; and behold, the Amlicites have joined them;

And they are upon our brethren in that land; and they are fleeing before them with their flocks, and their wives, and their children, towards our city; and except we make haste they obtain possession of our city, and our fathers, and our wives, and our children be slain.

And it came to pass that the people of Nephi took their tents, and departed out of the valley of Gideon towards their city, which was the city of Zarahemla.

27 Мөн болгоогтун, тэднийг Сидоны голыг гаталж байх зуур, тоо тоолшгүй олон леменчүүд болоод амлисайчууд, тэнгисийн элсний ширхэг мэт олноор, тэднийг устгахаар тэдний дээр ирэв.

28 Гэсэн хэдий ч, нифайчууд Их Эзэний мутраар хүчирхэгжиж, тэрээр тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлөөсэй хэмээн түүнд хүчтэйгээр залбирч байв, тиймийн тул Их Эзэн тэдний гуйлтыг сонсож, мөн тэднийг хүчирхэгжүүлэн, мөн леменчүүд болон амлисайчууд тэдний өмнө унасан болой.

29 Мөнхүү улиран тохиох дор Алма илдээр Амлисайтай халз тулалдав; мөн тэд өөр хоорондоо хүчтэйгээр тэмцэлдэв.

30 Мөнхүү улиран тохиох дор Алма, Бурханы хүн байж, их итгэлээ бодит болгосон байсны учир, гуйж, хэлрүүн: Ай Их Эзэн, би таны мутарт зэмсэг байж энэ хүмүүсийг аварч мөн хамгаалан үлдэж болохын тулд нигүүлсэж мөн амийг минь хэлтрүүлээч.

31 Эдүгээ Алма эдгээр үгсийг хэлээд тэрээр Амлисайтай дахин тэмцэлдэв; мөн тэрээр хүчирхэгжсэн байв, үүний хэрээр тэр Амлисайг илдээр хөнөөв.

32 Мөн түүнчлэн тэр леменчүүдийн хаантай тулалдав; гэвч леменчүүдийн хаан Алмагаас ухран зугтаж мөн харуулуудаа Алматай тэмцэлдүүлэхээр илгээв.

33 Харин Алма, харуулуудынхаа хамт, тэднийг хөнөөж мөн буцаан ухраатал леменчүүдийн хааны харуулуудтай тэрээр тэмцэлдсэн бөлгөө.

34 Мөн тийн тэр уг газрыг өөрөөр хэлбэл Сидон голын баруунтаах эргийг түүний хүмүүс голыг гатлан мөн леменчүүд болон амлисайчуудтай Сидон голын баруун эрэг дээр тэмцэлдэж болохын тулд алагдсан леменчүүдийн цогцсыг Сидоны усанд хаяж цэвэрлэв.

35 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд Сидон голыг гаталсны дараа леменчүүд хийгээд амлисайчууд тоологдсон байхын аргагүй тийм олон тоотой байсан хэдий ч тэдний өмнө зугтаж эхлэв.

36 Мөн тэд баруун хойд зүгт, уг нутгийн хилийн чанад дахь аглаг буйдын зүг чиглэн нифайчуудын өмнө зугтав; мөн нифайчууд тэднийг чадлаараа мөшгөж, мөн тэднийг хөнөөв.

And behold, as they were crossing the river Sidon, the Lamanites and the Amlicites, being as numerous almost, as it were, as the sands of the sea, came upon them to destroy them.

Nevertheless, the Nephites being strengthened by the hand of the Lord, having prayed mightily to him that he would deliver them out of the hands of their enemies, therefore the Lord did hear their cries, and did strengthen them, and the Lamanites and the Amlicites did fall before them.

And it came to pass that Alma fought with Amlici with the sword, face to face; and they did contend mightily, one with another.

And it came to pass that Alma, being a man of God, being exercised with much faith, cried, saying: O Lord, have mercy and spare my life, that I may be an instrument in thy hands to save and preserve this people.

Now when Alma had said these words he contended again with Amlici; and he was strengthened, insomuch that he slew Amlici with the sword.

And he also contended with the king of the Lamanites; but the king of the Lamanites fled back from before Alma and sent his guards to contend with Alma.

But Alma, with his guards, contended with the guards of the king of the Lamanites until he slew and drove them back.

And thus he cleared the ground, or rather the bank, which was on the west of the river Sidon, throwing the bodies of the Lamanites who had been slain into the waters of Sidon, that thereby his people might have room to cross and contend with the Lamanites and the Amlicites on the west side of the river Sidon.

And it came to pass that when they had all crossed the river Sidon that the Lamanites and the Amlicites began to flee before them, notwithstanding they were so numerous that they could not be numbered.

And they fled before the Nephites towards the wilderness which was west and north, away beyond the borders of the land; and the Nephites did pursue them with their might, and did slay them.



37 Тийм ээ, тэд өрнөдөд, мөн умардад тараагдах хүртлээ, тэд Хермаунтс гэж нэрлэгдсэн аглаг буйдад хүрэх хүртлээ, зүг бүрээсээ тэд тулгагдаж, мөн алуулж, туугдаж байв; мөн энэ нь зэрлэг хийгээд өлсгөлөн араатнуудаар эзлэгдсэн аглаг буйдын тэр хэсэг байсан болой.

38 Мөнхүү улиран тохиох дор тэдний олон нь шархнаасаа болж аглаг буйдад үхээд, мөн тэдгээр араатнууд мөн түүнчлэн тэнгэрт эргэлдэх тас шувуудад цөлмүүлсэн болой; мөн тэдний яс нь олдож, мөн газар овоологдсон байв.

Yea, they were met on every hand, and slain and driven, until they were scattered on the west, and on the north, until they had reached the wilderness, which was called Hermounts; and it was that part of the wilderness which was infested by wild and ravenous beasts.

And it came to pass that many died in the wilderness of their wounds, and were devoured by those beasts and also the vultures of the air; and their bones have been found, and have been heaped up on the earth.

## Алма 3

- 1 Мөнхүү улиран тохиох дор дайны зэвсэгт хөнөөгдөөгүй тэдгээр нифайчууд, хөнөөгдсөн тэднийг оршуулсны дараа—эдүгээ алагдагсдын тоо тоологдсонгүй, учир нь тэдний тоо агуу олон байв—тэд өөрсдийн амь үрэгдэгсдийг оршуулж дууссаны дараа нутагтаа, мөн гэртээ, мөн эхнэрүүддээ, мөн хүүхдүүддээ бүгд эргэж очицгоов.
- 2 Эдүгээ олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүд, мөн түүнчлэн тэдний бог болон бод малаас олон нь илдэнд алагдсан байв; мөн түүнчлэн тэдний үр тарианы талбайгаас олон нь устгагдав, учир нь тэд олон хүмүүсийн хөл доор гишгэгдсэн байлаа.
- 3 Мөн эдүгээ Сидон голын эрэг дээр алагдсан леменчүүд болон амлисайчууд бүгд Сидоны усанд хаягдав; мөн болгоогтун тэдний яс тэнгисийн гүнд буй, мөн тэдгээр нь олон буй.
- 4 Мөн амлисайчууд нифайчуудаас онцлогдов, учир нь тэд леменчүүдийн маягаар духан дээрээ улаанаар тэмдэг тавьсан байв; гэсэн хэдий ч тэд леменчүүдийн адил толгойн үсээ хуссан нь үгүй.
- 5 Эдүгээ леменчүүд толгойн үсээ хуссан байв; мөн тэдний хэвлийн тус бүсэлсэн арьс, мөн түүнчлэн тэдний зүүсэн хуяг, мөн тэдний нумнууд, мөн тэдний сумнууд, мөн тэдний чулуунууд, мөн тэдний дүүгүүрүүд гэхчлэнгээс бусдаар бол тэд нүцгэн байв.
- 6 Мөн тэдний эсэргүүцэл хийгээд тэдний зөрчлийн учир тэдэнд ирсэн зүхэл болох, тэдний эцэг өвгөдийн дээр тавигдсан тэмдгийн дагуу леменчүүдийн арьс бараан байв, шударга бөгөөд ариун хүмүүс асан Нифай, Иаков мөн Иосеф мөн Самаас бүрдсэн дүү нарынхаа эсрэг тэрхүү эсэргүүцэл мөн зөрчлийнх нь учир буюу.
- 7 Мөн ах нар нь тэднийг устгахыг эрэлхийлж, тиймийн тул тэд зүхэгдсэн бөлгөө; мөн Их Эзэн Бурхан тэдний дээр, тийм ээ, Лемен болон Лемүел, мөн түүнчлэн Ишмэилийн хөвгүүд, мөн Ишмэил үндэстний эмэгтэйчүүдийн дээр тэмдэг тавьжээ.

## Alma 3

And it came to pass that the Nephites who were not slain by the weapons of war, after having buried those who had been slain—now the number of the slain were not numbered, because of the greatness of their number—after they had finished burying their dead they all returned to their lands, and to their houses, and their wives, and their children.

Now many women and children had been slain with the sword, and also many of their flocks and their herds; and also many of their fields of grain were destroyed, for they were trodden down by the hosts of men.

And now as many of the Lamanites and the Amlicites who had been slain upon the bank of the river Sidon were cast into the waters of Sidon; and behold their bones are in the depths of the sea, and they are many.

And the Amlicites were distinguished from the Nephites, for they had marked themselves with red in their foreheads after the manner of the Lamanites; nevertheless they had not shorn their heads like unto the Lamanites.

Now the heads of the Lamanites were shorn; and they were naked, save it were skin which was girded about their loins, and also their armor, which was girded about them, and their bows, and their arrows, and their stones, and their slings, and so forth.

And the skins of the Lamanites were dark, according to the mark which was set upon their fathers, which was a curse upon them because of their transgression and their rebellion against their brethren, who consisted of Nephi, Jacob, and Joseph, and Sam, who were just and holy men.

And their brethren sought to destroy them, therefore they were cursed; and the Lord God set a mark upon them, yea, upon Laman and Lemuel, and also the sons of Ishmael, and Ishmaelitish women.

- 8 Мөн энэ нь тэдний үр удам тэдний дүү нарынх нь үр удмаас ялгагдаж болохын тулд хийгдсэн ажгуу, тэгснээр Их Эзэн Бурхан өөрийн хүмүүсийг хадгалан үлдээж болно хэмээн, өөрсдийг нь устгалд хүргэх зөв бус уламжлалуудад тэд холилдож мөн итгэхгүйн тулд буюу.
- 9 Мөнхүү улиран тохиох дор өөрийн үр удмыг леменчүүдийнхтэй холилдуулах хэн боловч үр удмынхаа дээр нэгэн адил зүхлийг авчирсан болой.
- 10 Тиймийн тул, өөрийгөө леменчүүдээр удирдуулахыг зөвшөөрсөн хэн боловч тэр овгийн дор нэрлэгдэж, мөн түүний дээр тэмдэг тавигдсан билээ.
- 11 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн уламжлалд үл итгэн, харин Иерусалим нутгаас авчрагдсан тэдгээр цэдгүүдэд мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө зөв болох тэрхүү уламжлалд итгэсэн, Бурханы зарлигуудад итгэж мөн тэдгээрийг дагасан хэн боловч, тэр цагаас хойш нифайчууд буюу Нифайн хүмүүс хэмээн нэрлэгдсэн бөлгөө—
- 12 Мөн өөрсдийн хүмүүсийн, мөн түүнчлэн леменчүүдийн ард түмний үнэн болох тэрхүү цэдгүүдийг хадгалсан нь тэд болой.
- 13 Эдүгээ бид амлисайчуудын тухай сэдэвтээ эргэж орё, учир нь тэд түүнчлэн дээрээ тэмдэгтэй байв; тийм ээ, тэд өөрсдийн дээр уг тэмдгийг, тийм ээ, бүр духан дээрээ улаан тэмдэг тавьсан аж.
- 14 Тийн Бурханы үг биелэгдсэн ажээ, учир нь Нифайд хэлсэн түүний үгс нь эдгээр болой: Болгоогтун, леменчүүдийг би зүхсэн, мөн тэд өөрсдийнхөө ёс бусыг наманчилж мөн тэдний дээр би нигүүлслийг үзүүлж болохын тул надад хандахаас бусдаар бол, энэ цагаас хойш мөн үүрд, тэд болон тэдний үр удам чамаас мөн чиний үр удмаас ялгагдаж болохын тулд тэдэн дээр би тэмдэг тавих болно.
- 15 Мөн үүнчлэн: Өөрийн үр удмыг ах дүүстэй чинь холилдуулах тэдний дээр, тэд түүнчлэн зүхэгдэж болохын тулд би тэмдэг тавих болно.
- 16 Мөн үүнчлэн: Би чиний мөн чиний үр удмын эсрэг тулалдах тэдэн дээр тэмдэг тавих болно.

And this was done that their seed might be distinguished from the seed of their brethren, that thereby the Lord God might preserve his people, that they might not mix and believe in incorrect traditions which would prove their destruction.

And it came to pass that whosoever did mingle his seed with that of the Lamanites did bring the same curse upon his seed.

Therefore, whosoever suffered himself to be led away by the Lamanites was called under that head, and there was a mark set upon him.

And it came to pass that whosoever would not believe in the tradition of the Lamanites, but believed those records which were brought out of the land of Jerusalem, and also in the tradition of their fathers, which were correct, who believed in the commandments of God and kept them, were called the Nephites, or the people of Nephi, from that time forth—

And it is they who have kept the records which are true of their people, and also of the people of the Lamanites.

Now we will return again to the Amlicites, for they also had a mark set upon them; yea, they set the mark upon themselves, yea, even a mark of red upon their foreheads.

Thus the word of God is fulfilled, for these are the words which he said to Nephi: Behold, the Lamanites have I cursed, and I will set a mark on them that they and their seed may be separated from thee and thy seed, from this time henceforth and forever, except they repent of their wickedness and turn to me that I may have mercy upon them.

And again: I will set a mark upon him that mingleth his seed with thy brethren, that they may be cursed also.

And again: I will set a mark upon him that fighteth against thee and thy seed.

17 Мөн үүнчлэн, чамаас салж одох тэрбээр чиний үр удам гэж дахин нэрлэгдэхгүйг би хэлнэ; мөн би чамайг, мөн чиний үр удам гэж нэрлэгдэх хэнийг боловч, цаашид мөн үүрд адислах болно; мөн эдгээр нь Нифай мөн түүний үр удамд өгсөн Их Эзэний амлалтууд байв.

18 Эдүгээ тэд духан дээрээ тэмдэг тавьж эхлэхдээ амлисайчууд тэд Бурханы үгийг биелүүлснээ мэдсэнгүй; гэсэн хэдий ч тэд Бурханы эсрэг илэрхий эсэргүүцэлд гарч ирсэн байв; тиймийн тул зүхэл тэдний дээр унах нь зайлшгүй байсан бөлгөө.

19 Эдүгээ тэд өөрсдийнхөө дээр зүхлийг авчирсныг та нар ойлгоосой хэмээнэ би; мөн тэрчлэн зүхэгдсэн хүн бүр өөрийн ялыг өөр дээрээ авчирдаг.

20 Эдүгээ улиран тохиох дор леменчүүд болон амлисайчуудаар Зарахемла нутагт өдөөгдсөн тэр тулаанаас тийм ч олон бус өдрийн дараа, анхны их цэрэг нь амлисайчуудын цэрэгтэй тулгарсан мөнхүү тэр газар леменчүүдийн өөр нэг их цэрэг Нифайн хүмүүсийн дээр ирэв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэднийг нутгаасаа хөөж гаргахын тулд их цэрэг илгээгдэв.

22 Эдүгээ Алма шархандаа шаналж байсан учир энэ удаа леменчүүдийн эсрэг тулалдаанд өөрөө явсангүй;

23 Гэвч тэр олон тооны их цэргийг тэдний эсрэг илгээв; мөн тэд өгсөн одож мөн леменчүүдээс олныг нь алж, мөн тэднээс үлдсэнийг нь нутгийнхаа хилээс үлдэн хөөв.

24 Мөн тэгээд тэд дахин эргэж ирээд мөн уг нутагт амар амгаланг тогтоож эхлэв, хэсэг хугацаагаар дайснууд нь дахин тэднийг түйвүүлээгүйн учир болой.

25 Эдүгээ эдгээр бүх зүйл хийгдэв, тийм ээ, эдгээр бүх дайн мөн тэмцлүүд шүүгчдийн засаглалын тав дахь онд эхэлж мөн төгсөв.

26 Мөн тэд сайн байсан эсэхээс эсвээс тэд муу байсан эсэхээс, өөрсдийн үйлүүдийн дагуу шагналуудаа хадгаж болохын тулд, сайн эсвээс муу сүнс байхаас хамааран, тэд дагахаар шийдсэн тэрхүү сүнснийхээ дагуу, мөнхийн аз жаргалыг, эсвээс мөнхийн зовлонг тэд хадан авахаар нэгэн жилд мянга мянган мөн хэдэн арван мянган бодгаль мөнхийн оронд илгээгдэв.

And again, I say he that departeth from thee shall no more be called thy seed; and I will bless thee, and whomsoever shall be called thy seed, henceforth and forever; and these were the promises of the Lord unto Nephi and to his seed.

Now the Amlicites knew not that they were fulfilling the words of God when they began to mark themselves in their foreheads; nevertheless they had come out in open rebellion against God; therefore it was expedient that the curse should fall upon them.

Now I would that ye should see that they brought upon themselves the curse; and even so doth every man that is cursed bring upon himself his own condemnation.

Now it came to pass that not many days after the battle which was fought in the land of Zarahemla, by the Lamanites and the Amlicites, that there was another army of the Lamanites came in upon the people of Nephi, in the same place where the first army met the Amlicites.

And it came to pass that there was an army sent to drive them out of their land.

Now Alma himself being afflicted with a wound did not go up to battle at this time against the Lamanites;

But he sent up a numerous army against them; and they went up and slew many of the Lamanites, and drove the remainder of them out of the borders of their land.

And then they returned again and began to establish peace in the land, being troubled no more for a time with their enemies.

Now all these things were done, yea, all these wars and contentions were commenced and ended in the fifth year of the reign of the judges.

And in one year were thousands and tens of thousands of souls sent to the eternal world, that they might reap their rewards according to their works, whether they were good or whether they were bad, to reap eternal happiness or eternal misery, according to the spirit which they listed to obey, whether it be a good spirit or a bad one.

27 Учир нь хүн бүр дагахаар сонгосон түүнээсээ шангаа хүлээж авдаг, мөн энэ нь бошиглолын суу билгийн үгсийн дагуу буюу; тиймийн тул энэ нь үнэний дагуу байг. Мөн тийн шүүгчдийн засаглалын тавдахь он төгсөв.

For every man receiveth wages of him whom he listeth to obey, and this according to the words of the spirit of prophecy; therefore let it be according to the truth. And thus endeth the fifth year of the reign of the judges.

## Алма 4

- 1 Эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын зургадугаар онд, Зарахемлагийн нутагт тэмцлүүд ч мөн дайнууд ч байсангүй;
- 2 Гэвч хүмүүс зүдэрч байв, тийм ээ, ах дүүсээ алдсаны учир, мөн түүнчлэн бог мөн бод малаа алдсаны учир, мөн түүнчлэн леменчүүдийн хөл дор гишгэгдэж мөн устгагдсан үр тарианы талбайнуудаа алдсан учир маш ихээр зүдэрч байсан бөлгөө.
- 3 Мөн тэдний зүдгүүрүүд тийм агуу их байсны улмаас бодгаль бүхэнд гашуудах шалтгаан болов; мөн энэ нь тэдний ёс бус хийгээд мөн тэдний жигшүүрт хэргүүдийн учир тэдэн дээр илгээгдсэн Бурханы шүүлтүүд байсан гэдэгт тэд итгэжээ; тиймийн тул тэд үүргийнхээ санамжинд сэрээгдсэн болой.
- 4 Мөн тэд сүмийг илүү бүрнээр нь байгуулж эхлэв; тийм ээ, мөн Сидоны усанд олон нь баптисм хүртэж мөн Бурханы сүмд нэгдэв; тийм ээ, эцэг Алмагийнхаа гараар, сүмийн хүмүүсийн дээр дээд санваартнаар ариулан адислагдсан Алмагийн гараар тэд баптисм хүртсэн ажээ.
- 5 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын долоо дахь жилд өөрсдийгөө Бурханы сүмд нэгтгэж мөн баптисм хүртсэн гурван мянга таван зуу орчим бодгаль байв. Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын долоо дахь он төгсөв; мөн тэр бүх үед үргэлжийн амгалан байв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын найм дахь онд, өөрсдийн хөдөлмөрөөр олж авсан тэр үлэмжийн их баялаг, мөн сайн чанарын торгонууд, мөн нарийн нэхээст эдийнхээ учир, мөн олон бог мөн бод мал, мөн алт болон мөнгөнийхөө, мөн төрөл бүрийн үнэт зүйлүүдийнхээ учир сүмийн хүмүүс бардам сэхүүн болж эхлэв; мөн эдгээр бүх зүйлийн учир тэд нүдэн дэх бардамналдаа хөөрсөн байв, учир нь тэд үлэмж үнэтэй хувцас өмсөж эхлэв.
- 7 Эдүгээ энэ нь Алмад, тийм ээ, мөн сүмийн багш нар, мөн санваартнууд, мөн ахлагчид байхаар Алмагийн томилсон тэдгээр хүмүүсийн олонд нь их зүдгүүрийн шалтгаан байв; тийм ээ, тэдний олон нь өөрсдийн хүмүүсийн дунд эхэлсэн ёс бусыг харсан учир ихээр шаналж байв.

## Alma 4

Now it came to pass in the sixth year of the reign of the judges over the people of Nephi, there were no contentions nor wars in the land of Zarahemla;

But the people were afflicted, yea, greatly afflicted for the loss of their brethren, and also for the loss of their flocks and herds, and also for the loss of their fields of grain, which were trodden under foot and destroyed by the Lamanites.

And so great were their afflictions that every soul had cause to mourn; and they believed that it was the judgments of God sent upon them because of their wickedness and their abominations; therefore they were awakened to a remembrance of their duty.

And they began to establish the church more fully; yea, and many were baptized in the waters of Sidon and were joined to the church of God; yea, they were baptized by the hand of Alma, who had been consecrated the high priest over the people of the church, by the hand of his father Alma.

And it came to pass in the seventh year of the reign of the judges there were about three thousand five hundred souls that united themselves to the church of God and were baptized. And thus ended the seventh year of the reign of the judges over the people of Nephi; and there was continual peace in all that time.

And it came to pass in the eighth year of the reign of the judges, that the people of the church began to wax proud, because of their exceeding riches, and their fine silks, and their fine-twined linen, and because of their many flocks and herds, and their gold and their silver, and all manner of precious things, which they had obtained by their industry; and in all these things were they lifted up in the pride of their eyes, for they began to wear very costly apparel.

Now this was the cause of much affliction to Alma, yea, and to many of the people whom Alma had consecrated to be teachers, and priests, and elders over the church; yea, many of them were sorely grieved for the wickedness which they saw had begun to be among their people.

- 8 Учир нь сүмийн хүмүүс өөрсдийн нүдэн дэх бардамналдаа хөөрцөглөж, мөн зүрх сэтгэлээ баялаг дээр мөн дэлхийн дэмий хоосон зүйлүүд дээр суурилуулж эхэлсэн аж, тиймээс тэд бие биенээ тохуурхах болов, мөн тэдний хүсэл мөн тааллын дагуу сүсэглээгүй тэднийг хавчиж эхэлснийг их харамсалтайгаар тэд харж бас болгоов.
- 9 Мөн тийн, шүүгчдийн засаглалын энэ найм дахь онд, сүмийн хүмүүсийн дунд их тэмцлүүд гарч эхлэв; тийм ээ, атаа жөтөө мөн маргаан мэтгэлцээн, мөн өс хонзон, мөн хавчлага, мөн бардамнал, бүр Бурханы сүмд харьяалагдаагүй тэднийхээс илүү бардамнал байлаа.
- 10 Мөн тийн шүүгчдийн засаглалын найм дахь он төгсөв; мөн сүмийн ёс бус сүмд харьяалагдаагүй тэдэнд агуу тээглэх чулуу болж байв; мөн тийн сүм дэвшилдээ удааширч эхлэв.
- 11 Мөнхүү улиран тохиох дор ес дэх жилийн эхлэлд, Алма сүмийн ёс бус байдлыг харав, мөн түүнчлэн сүмийн тэр үлгэр жишээ нь үл итгэгчдийг нэг алдсаас нөгөөд удирдаж эхлэн, тийн хүмүүсийн устгалыг ойртуулж буйг тэрээр үзэв.
- 12 Тийм ээ, тэрээр хүмүүсийн дундах агуу тэгш бус байдлыг, зарим нь өөрсдийн нүдэн дэх бардамналдаа хөөрч, бусдыг гадуурхаж, гачигдсан мөн нүцгэн мөн өлсгөлөн тэдэнд, мөн цангасан тэдэнд, мөн өвдөж зовсон тэдэнд араа харуулахыг харав.
- 13 Эдүгээ энэ нь хүмүүсийн дунд агуу харамсал гашуудлын шалтгаан болж байв, бусад зарим нь өөрсдийгөө даруухнаар үзэж, өөрсдийн хөрөнгийг ядуус хийгээд гачигдагсдад хүртээн, өлссөнийг хооллох зэргээр, тэдний халамжаар гачигдах тэднийг халамжилж, мөн бүх төрлийн зүдрэлийг бошиглолын суу билгийн дагуу ирэх ёстой тэр, Христийн төлөө тэсвэрлэсэн буюу;
- 14 Тэр өдрийг харуулдан хүлээж; Есүс Христ үхлийн хүлээснээс чөлөөлөх явдал мөн хүч чадал мөн тааллын дагуу, үхэгсдийн амилуулалтын учир агуу их баяслаар дүүргэгдэж байх зуур, тийн нүглүүдийнхээ ангижралыг хадгалсан ажгуу.

For they saw and beheld with great sorrow that the people of the church began to be lifted up in the pride of their eyes, and to set their hearts upon riches and upon the vain things of the world, that they began to be scornful, one towards another, and they began to persecute those that did not believe according to their own will and pleasure.

And thus, in this eighth year of the reign of the judges, there began to be great contentions among the people of the church; yea, there were envyings, and strife, and malice, and persecutions, and pride, even to exceed the pride of those who did not belong to the church of God.

And thus ended the eighth year of the reign of the judges; and the wickedness of the church was a great stumbling-block to those who did not belong to the church; and thus the church began to fail in its progress.

And it came to pass in the commencement of the ninth year, Alma saw the wickedness of the church, and he saw also that the example of the church began to lead those who were unbelievers on from one piece of iniquity to another, thus bringing on the destruction of the people.

Yea, he saw great inequality among the people, some lifting themselves up with their pride, despising others, turning their backs upon the needy and the naked and those who were hungry, and those who were athirst, and those who were sick and afflicted.

Now this was a great cause for lamentations among the people, while others were abasing themselves, succoring those who stood in need of their succor, such as imparting their substance to the poor and the needy, feeding the hungry, and suffering all manner of afflictions, for Christ's sake, who should come according to the spirit of prophecy;

Looking forward to that day, thus retaining a remission of their sins; being filled with great joy because of the resurrection of the dead, according to the will and power and deliverance of Jesus Christ from the bands of death.

15 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма, Бурханы даруухан дагалдагчдын зовлонгуудыг мөн бусад хүмүүсийнхээ тэдний дээр овоолсон тэр хавчлагуудыг харж, мөн тэдний бүх тэгш бус байдлыг харсан учир, маш их харамсаж эхлэв; гэсэн хэдий ч Их Эзэний Сүнс түүнийг орхисонгүй.

16 Мөн тэрээр сүмийн ахлагчдын дунд байсан мэргэн нэгнийг сонгон авч, мөн өгөгдсөн хуулиудын дагуу тэрээр хуулиудыг тогтоож, мөн тэдгээрийг хүмүүсийн ёс бус байдал хийгээд гэмт хэргүүдийн дагуу хэрэгжүүлэх хүчтэй байж болохын тулд хүмүүсийн саналын дагуу түүнд хүчийг өгөв.

17 Эдүгээ энэ хүний нэр Нифайха байв, мөн тэрээр ерөнхий шүүгчээр томилогдов; мөн тэр хүмүүсийг шүүж мөн засаглахаар шүүгчийн суудалд суув.

18 Эдүгээ Алма сүмийн дээрх дээд санваартны албыг түүнд өгсөнгүй, харин тэр дээд санваартны албыг өөртөө хадгалж үлдээв; гэвч тэр шүүгчийн суудлыг Нифайхад өгсөн бөлгөө.

19 Мөн тэр өөрөө хүмүүсийнхээ дунд, өөрөөр хэлбэл Нифайн хүмүүсийн дунд одож болохын тулд, тэдэнд үүргийг нь сануулахаар өдөөж, тэдэнд Бурханы үгийг номлож болохын тулд, мөн түүний хүмүүсийн дунд байсан бүх бардамнал мөн башир арга хийгээд бүх тэмцлүүдийг Бурханы үгээр намжааж болохын тулд тэрээр үүнийг хийсэн болой, учир нь тэдний эсрэг шударга гэрчлэлийг үзүүлэхээс бусдаар тэднийг буцааж авах өөр замыг тэр харсангүй.

20 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын ес дэх жилийн эхлэлд, Алма шүүгчийн суудлыг Нифайхад дамжуулж, мөн өөрийгөө тэр чигээр нь Бурханы ариун жаягийн дээд санваарт, илчлэлтийн мөн бошиглолын суу билгийн дагуу, үгийн гэрчлэлд зориулав.

And now it came to pass that Alma, having seen the afflictions of the humble followers of God, and the persecutions which were heaped upon them by the remainder of his people, and seeing all their inequality, began to be very sorrowful; nevertheless the Spirit of the Lord did not fail him.

And he selected a wise man who was among the elders of the church, and gave him power according to the voice of the people, that he might have power to enact laws according to the laws which had been given, and to put them in force according to the wickedness and the crimes of the people.

Now this man's name was Nephiah, and he was appointed chief judge; and he sat in the judgment-seat to judge and to govern the people.

Now Alma did not grant unto him the office of being high priest over the church, but he retained the office of high priest unto himself; but he delivered the judgment-seat unto Nephiah.

And this he did that he himself might go forth among his people, or among the people of Nephi, that he might preach the word of God unto them, to stir them up in remembrance of their duty, and that he might pull down, by the word of God, all the pride and craftiness and all the contentions which were among his people, seeing no way that he might reclaim them save it were in bearing down in pure testimony against them.

And thus in the commencement of the ninth year of the reign of the judges over the people of Nephi, Alma delivered up the judgment-seat to Nephiah, and confined himself wholly to the high priesthood of the holy order of God, to the testimony of the word, according to the spirit of revelation and prophecy.



*Бурханы ариун жаягийн дагуу Дээд санваартан болох Алмагийн уг нутаг даяар тэдний хотууд мөн тосгодын хүмүүст хүргэсэн үгс оривой.*

## Алма 5

- 1 Эдүгээ улиран тохиох дор Алма хүмүүст Бурханы үгийг, эхлээд Зарахэмлагийн нутагт, мөн тэндээсээ бүх нутаг даяар хүргэж эхлэв.
- 2 Мөн Зарахемла хотод байгуулагдсан сүмийн хүмүүст түүний ярьсан үгс нь эдгээр бөлгөө, түүний өөрийнх нь цэдгийн дагуу, өгүүлсэн нь:
- 3 Би, Алма, өөрийн эцэг Алмагаар Бурханы сүмийн дээрх дээд санваартан байхаар томилогдон адислагдсан билээ, учир нь түүнд эдгээр зүйлийг хийх хүч чадал мөн эрх мэдэл Бурханаас өгөгдсөн юм, болгоогтун, тэр Нифайн хилийн дотор байсан нутагт тэрээр сүм байгуулж эхэлснийг би та нарт хэлнэ; тийм ээ, Мормоны нутаг гэж нэрлэгдсэн тэрхүү нутагт; тийм ээ, мөн тэрээр ах дүүстээ Мормоны Усанд баптисм хүртээсэн болой.
- 4 Мөн болгоогтун, би та нарт хэлнэ, тэд Бурханы нигүүлсэл мөн хүчээр, хаан Ноагийн хүмүүсийн гараас чөлөөлөгдсөн билээ.
- 5 Мөн болгоогтун, түүний дараа, тэд аглаг буйдад леменчүүдийн гараар дарангуйлалд авчрагдсан юм; тийм ээ, би та нарт хэлнэ, тэд боолчлолд байв, мөн Их Эзэн тэднийг өөрийн үгний хүчээр дарангуйллаас дахин чөлөөлсөн болой; мөн бид энэ нутагт авчрагдаж, мөн энд бид Бурханы сүмийг түүнчлэн энэ бүх нутаг даяар байгуулж эхэлсэн билээ.
- 6 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, ах дүүс минь, энэ сүмд харъяалагддаг та нар, та нар эцэг өвгөдийнхөө боолчлолыг хангалттайгаар санасаар байдаг уу? Тийм ээ, мөн тэдэнд хандсан түүний нигүүлсэл хийгээд тэсвэрийг та нар хангалттайгаар санасаар байдаг уу? Мөн үүнээс гадна, та нар тэдний бодгалиудыг тэрээр тамаас чөлөөлснийг хангалттай санасаар байдаг уу

*The words which Alma, the High Priest according to the holy order of God, delivered to the people in their cities and villages throughout the land.*

## Alma 5

Now it came to pass that Alma began to deliver the word of God unto the people, first in the land of Zarahemla, and from thence throughout all the land.

And these are the words which he spake to the people in the church which was established in the city of Zarahemla, according to his own record, saying:

I, Alma, having been consecrated by my father, Alma, to be a high priest over the church of God, he having power and authority from God to do these things, behold, I say unto you that he began to establish a church in the land which was in the borders of Nephi; yea, the land which was called the land of Mormon; yea, and he did baptize his brethren in the waters of Mormon.

And behold, I say unto you, they were delivered out of the hands of the people of king Noah, by the mercy and power of God.

And behold, after that, they were brought into bondage by the hands of the Lamanites in the wilderness; yea, I say unto you, they were in captivity, and again the Lord did deliver them out of bondage by the power of his word; and we were brought into this land, and here we began to establish the church of God throughout this land also.

And now behold, I say unto you, my brethren, you that belong to this church, have you sufficiently retained in remembrance the captivity of your fathers? Yea, and have you sufficiently retained in remembrance his mercy and long-suffering towards them? And moreover, have ye sufficiently retained in remembrance that he has delivered their souls from hell?

7 Болгоогтун, тэрээр тэдний зүрх сэтгэлийг өөрчилсөн, тийм ээ, тэр тэднийг гүн нойрноос сэрээсэн, мөн тэд Бурханы хувьд сэрсэн. Болгоогтун, тэд харанхуйн дунд байсан; гэсэн хэдий ч, тэдний бодгалиуд үүрдийн үгийн гэрлээр гэрэлтүүлэгдсэн билээ; тийм ээ, тэд үхлийн хүлээсээр, мөн тамын гинжээр ороогдсон байж, мөн үүрдийн устгал тэднийг хүлээж байв.

8 Мөн эдүгээ би та нараас асууя, ах дүүс минь, тэд устгагдсан уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй, тэд устгагдаагүй.

9 Мөн үүнчлэн би асууна, үхлийн хүлээс таслагдаж мөн тэднийг ороосон тамын гинжүүд, тэдгээр нь тайлагдсан уу? Би та нарт хэлнэ, Тийм ээ, тэдгээр нь тайлагдсан, мөн тэдний бодгалиуд баясалд тэлж, мөн тэд гэтэлгэх хайрыг дуулах болов. Мөн тэд аврагдсаныг би та нарт хэлнэ.

10 Мөн эдүгээ тэд ямар нөхцөлийн дор аврагдсаныг би та нараас асууя? Тийм ээ, авралын төлөө найдах ямар үндэслэл тэдэнд байгаа билээ? Тэднийг үхлийн хүлээснээс, тийм ээ, мөн түүнчлэн тамын гинжнээс сулласан шалтгаан нь юу билээ

11 Болгоогтун, би та нарт хэлж чадна—Абинадайн амаар яригдсан үгсэд миний эцэг Алма итгээгүй гэж үү? Мөн тэрээр ариун бошиглогч байгаагүй гэж үү? Тэрээр Бурханы үсгийг ярьж, тэгээд миний эцэг Алма тэдгээрт итгээгүй гэж үү

12 Мөн өөрийнх нь итгэлийн дагуу түүний зүрх сэтгэлд хүчит өөрчлөлт бий болгогдсон бөлгөө. Болгоогтун, энэ бүгд үнэнийг би та нарт хэлнэ.

13 Мөн болгоогтун, тэрээр та нарын эцэг өвгөдөд үгийг номлож, мөн түүнчлэн тэдний зүрх сэтгэлд ч хүчит өөрчлөлт бий болгогдож, мөн тэд өөрсдийгөө даруусган мөн үнэн болоод амьд Бурханд найдлагаа тавьсан бөлгөө. Мөн болгоогтун, тэд эцсийг хүртэл итгэлтэй байсан; тиймийн тул тэд аврагдав.

14 Мөн эдүгээ болгоогтун, би та нараас асууя, сүмийн ах дүүс минь, та нар сүнслэг байдлаараа Бурханаас төрсөн үү? Та нар түүний дүр төрхийг царай төрхөндөө хүлээж авсан уу? Та нар энэ хүчит өөрчлөлтийг зүрх сэтгэлээрээ эдэлсэн үү

Behold, he changed their hearts; yea, he awakened them out of a deep sleep, and they awoke unto God. Behold, they were in the midst of darkness; nevertheless, their souls were illuminated by the light of the everlasting word; yea, they were encircled about by the bands of death, and the chains of hell, and an everlasting destruction did await them.

And now I ask of you, my brethren, were they destroyed? Behold, I say unto you, Nay, they were not.

And again I ask, were the bands of death broken, and the chains of hell which encircled them about, were they loosed? I say unto you, Yea, they were loosed, and their souls did expand, and they did sing redeeming love. And I say unto you that they are saved.

And now I ask of you on what conditions are they saved? Yea, what grounds had they to hope for salvation? What is the cause of their being loosed from the bands of death, yea, and also the chains of hell?

Behold, I can tell you—did not my father Alma believe in the words which were delivered by the mouth of Abinadi? And was he not a holy prophet? Did he not speak the words of God, and my father Alma believe them?

And according to his faith there was a mighty change wrought in his heart. Behold I say unto you that this is all true.

And behold, he preached the word unto your fathers, and a mighty change was also wrought in their hearts, and they humbled themselves and put their trust in the true and living God. And behold, they were faithful until the end; therefore they were saved.

And now behold, I ask of you, my brethren of the church, have ye spiritually been born of God? Have ye received his image in your countenances? Have ye experienced this mighty change in your hearts?

- 15 Та нарыг бүтээсэн түүний гэтэлгэлд та нар итгэлийг хөгжүүлдэг үү? Та нар итгэлийн нүдээр урьдаас харж энэ зуурдын бие үхэшгүй байдалд босгогдохыг, мөн энэ ялзрал муудашгүй болохыг, Бурханы өмнө зуурдын биед байхдаа хийсэн үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр зогсохыг төсөөлдөг үү
- 16 Би та нарт хэлнэ, та нар тэр өдөр: Адислагдсан та нар надад ирэгтүн, учир нь болгоогтун, газар дэлхийн гадаргуу дээрх та нарын үйлүүд зөв шударгын үйлс байлаа хэмээн та нарт хэлэх Их Эзэний дуу хоолойг сонсоно хэмээн өөрсдөдөө төсөөлж чадах уу
- 17 Эсвээс та нар тэр өдөр—Их Эзээн, бидний үйлс газар дэлхийн гадаргуу дээр зөв шударга байсан шүү дээ хэмээн Их Эзэнд худал хэлэхэд—мөн тэр та нарыг аврах болно хэмээн өөрсдөдөө төсөөлдөг үү
- 18 Эсвээс өөрөөр, та нарын бодгаль гэм болоод харамслаар дүүргэгдэж, өөрсдийн бүх гэрийн санамж, тийм ээ, өөрсдийн бүх ёс бусын төгс санамж, тийм ээ, Бурханы зарлигуудыг дагахаас татгалзсаныхаа санамжтайгаар Бурханы индрийн өмнө аваачигдаж буйгаар та нар өөрсдийгөө төсөөлж чадах уу
- 19 Би та нарт хэлнэ, тэр өдөр та нар ариун зүрх мөн цэвэр гартайгаар Бурхан өөд харж чадах уу? Би та нарт хэлнэ, Бурханы дүр төрхийг царай төрхөндөө шингээгээд өөд харж чадах уу
- 20 Би та нарт хэлнэ, та нар өөрсдийгөө чөтгөрийн хараат болгохоор бууж өгчихөөд аврагдах талаар бодож чадах уу
- 21 Би та нарт хэлнэ, та нар аврагдаж чадахгүйгээ тэр өдөр мэдэх болно; учир нь өмсгөлүүд нь цагаан болгож угаагдахаас бусдаар нэгээхэн ч хүмүүн аврагдаж чадахгүй; тийм ээ, өөрийн хүмүүсийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирэх, бидний эцэг өвгөдөөр яригдсан түүний цусаар бүх толбоноос цэвэршигдэх хүртлээ өмсгөлүүд ариутгагдах ёстой.
- 22 Мөн эдүгээ би та нараас асууя, ах дүүс минь, өмсгөлүүд тань цусаар мөн бүх төрлийн бузар муухайгаар толботуулагдсан байдалтайгаар та нар Бурханы тавцангийн өмнө зогсох болбол та нарын хэнд чинь ч гэсэн ямар санагдах билээ? Болгоогтун, эдгээр зүйлүүд та нарын эсрэг юуг гэрчлэх билээ

Do ye exercise faith in the redemption of him who created you? Do you look forward with an eye of faith, and view this mortal body raised in immortality, and this corruption raised in incorruption, to stand before God to be judged according to the deeds which have been done in the mortal body?

I say unto you, can you imagine to yourselves that ye hear the voice of the Lord, saying unto you, in that day: Come unto me ye blessed, for behold, your works have been the works of righteousness upon the face of the earth?

Or do ye imagine to yourselves that ye can lie unto the Lord in that day, and say—Lord, our works have been righteous works upon the face of the earth—and that he will save you?

Or otherwise, can ye imagine yourselves brought before the tribunal of God with your souls filled with guilt and remorse, having a remembrance of all your guilt, yea, a perfect remembrance of all your wickedness, yea, a remembrance that ye have set at defiance the commandments of God?

I say unto you, can ye look up to God at that day with a pure heart and clean hands? I say unto you, can you look up, having the image of God engraven upon your countenances?

I say unto you, can ye think of being saved when you have yielded yourselves to become subjects to the devil?

I say unto you, ye will know at that day that ye cannot be saved; for there can no man be saved except his garments are washed white; yea, his garments must be purified until they are cleansed from all stain, through the blood of him of whom it has been spoken by our fathers, who should come to redeem his people from their sins.

And now I ask of you, my brethren, how will any of you feel, if ye shall stand before the bar of God, having your garments stained with blood and all manner of filthiness? Behold, what will these things testify against you?

- 23 Болгоогтун тэдгээр нь та нарыг алуурчид хэмээн, тийм ээ, мөн түүнчлэн та нарыг зүйл бүрийн ёсон бусын гэмтэй хэмээн гэрчлэхгүй гэж үү
- 24 Болгоогтун, ах дүүс минь, өмсгөлүүд нь цэвэрлэгдсэн мөн ямар ч толбогүй, цэвэр мөн цагаан болох Абрахамтай, Исаактай, мөн Иаковтай хамт мөн түүнчлэн бүх ариун бошиглогчидтой хамт, Бурханы хаант улсад суух газар тийм нэгэнд байж чадна гэж та нар боддог
- 25 Би та нарт хэлнэ, Үгүй; Бүтээгчийг минь эхлэлээс худалч болгохоос, эсвэл эхлэлээс худалч байсан гэж бодохоос бусдаар, тиймүүд нь тэнгэрийн хаант улсад байрлаж чадна хэмээн та нар бодож болохгүй; харин тэд хөөгдөх болно, учир нь тэд чөтгөрийн хаант улсын хүүхдүүд бөлгөө.
- 26 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, ах дүүс минь, хэрэв та нар зүрх сэтгэлийн өөрчлөлтийг эдэлсэн бол, мөн хэрэв та нар гэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдсан бол, би асууя, та нар одоо тийн мэдэрч чадна уу
- 27 Та нар Бурханы өмнө өөрсдийгөө өө сэвгүй байлган, алхалсан уу? Хэрэв та нар энэ цагт үхэхээр дуудагдвал, та нар хангалттай даруухан байсан хэмээн өөрсдөдөө хэлж чадах сан болов уу? Өөрийн хүмүүсийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирэх Христийн цусаар өмсгөлүүд тань цэвэршигдэж, цагаан болгогдсон гэх үү
- 28 Болгоогтун, та нар бардамналаасаа ангижирсан уу? Би та нарт хэлнэ, хэрэв та нар тэгээгүй бол та нар Бурхантай уулзахад бэлтгэгдээгүй байна. Болгоогтун, та нар хурдхан бэлтгэх ёстой; учир нь тэнгэрийн хаант улс удахгүй ирнэ, мөн тийм нэгэн нь мөнх амьдралыг авахгүй бөлгөө.
- 29 Болгоогтун, би хэлнэ, та нарын дунд агаа жөтөөнөөсөө ангижраагүй нэгэн байна уу? Тийм нэгэн нь бэлтгэгдээгүй хэмээн би та нарт хэлнэ; мөн би түүнийг хурдхан бэлтгээсэй хэмээнэ, учир нь цаг ойрхон болж, мөн тэрээр цаг нь хэзээ ирэхийг мэдэхгүй байгаа; учир нь тийм нэг нь гэмгүй хэмээн тогтоогдохгүй.
- 30 Мөн түүнчлэн би та нарт хэлнэ, та нарын дунд ах дүүсээрээ доог хийдэг, эсвээс түүний дээр хавчлага овоолдог нэгэн нь байна уу

Behold will they not testify that ye are murderers, yea, and also that ye are guilty of all manner of wickedness?

Behold, my brethren, do ye suppose that such an one can have a place to sit down in the kingdom of God, with Abraham, with Isaac, and with Jacob, and also all the holy prophets, whose garments are cleansed and are spotless, pure and white?

I say unto you, Nay; except ye make our Creator a liar from the beginning, or suppose that he is a liar from the beginning, ye cannot suppose that such can have place in the kingdom of heaven; but they shall be cast out for they are the children of the kingdom of the devil.

And now behold, I say unto you, my brethren, if ye have experienced a change of heart, and if ye have felt to sing the song of redeeming love, I would ask, can ye feel so now?

Have ye walked, keeping yourselves blameless before God? Could ye say, if ye were called to die at this time, within yourselves, that ye have been sufficiently humble? That your garments have been cleansed and made white through the blood of Christ, who will come to redeem his people from their sins?

Behold, are ye stripped of pride? I say unto you, if ye are not ye are not prepared to meet God. Behold ye must prepare quickly; for the kingdom of heaven is soon at hand, and such an one hath not eternal life.

Behold, I say, is there one among you who is not stripped of envy? I say unto you that such an one is not prepared; and I would that he should prepare quickly, for the hour is close at hand, and he knoweth not when the time shall come; for such an one is not found guiltless.

And again I say unto you, is there one among you that doth make a mock of his brother, or that heapeth upon him persecutions?

31 Тийм нэгэнд халаг, учир нь тэр бэлтгэгдээгүй, мөн тэрээр наманчлах ёстой эс бөгөөс тэр аврагдаж чадахгүй тэр цаг ойрхон болжээ!

32 Тийм ээ, бүр алдсыг үйлдэгчид та нарт бүгдэд нь халаг; наманчлагтун, наманчлагтун, учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ!

33 Болгоогтун, тэрээр бүх хүмүүнд урилга илгээдэг, учир нь нигүүлслийн мутар тэдний зүг сунгагдаж, мөн тэрээр: Наманчлагтун, мөн би та нарыг хүлээн авах болно хэмээн хэлэх болно.

34 Тийм ээ, тэрээр хэлэв: Надад ирэгтүн мөн та нар амьдралын модны үр жимснээс хүртэх болно; тийм ээ, та нар үнэгүйгээр амьдралын талх мөн уснаас идэж мөн уух болно;

35 Тийм ээ, надад ирэгтүн мөн зөв шударгын үйлүүдийг авчрагтун, мөн та нар цавчигдаж мөн галд хаягдахгүй байх болно—

36 Учир нь болгоогтун, сайн үр жимсийг авчирдаггүй хэн боловч, өөрөөр хэлбэл зөв шударгын үйлүүдийг хийдэггүй хэн боловч, мөнхүү тэр нь орь дуу тавих мөн гашуудах шалтгаан бүхий байх тэр цаг ойрхон байнам.

37 Ай алдсыг үйлдэгчид та нар; дэлхийн хоосон зүйлүүдээр ааглагдсан та нар, зөв шударгын замуудыг мэдсэн дүр эсгэдэг хэдий ч хоньчингүй хонь мэт төөрч одсон, үнэн хэрэгтээ хоньчин та нарын араас дуудаж байсан мөн та нарын араас дуудсаар л буй, гэвч та нар түүний дуу хоолойг сонсохгүй шүү дээ!

38 Болгоогтун, би та нарт хэлнэ, сайн хоньчин та нарыг дууддаг; тийм ээ, мөн Христийн нэр болох өөрийнхөө нэрээр та нарыг тэр дууддаг; мөн хэрэв та нар сайн хоньчны дуу хоолойг, та нарын дуудагдах тэрхүү нэрийг сонсохгүй бол, болгоогтун, та нар сайн хоньчны хонь биш.

39 Мөн эдүгээ хэрэв та нар сайн хоньчны хонь бус аваас, та нар аль сүргийнх вэ? Болгоогтун, би та нарт хэлнэ, чөтгөр бол та нарын хоньчин, мөн та нар түүний сүргийнх; мөн эдүгээ, үүнийг хэн үгүйсгэж чадах билээ? Болгоогтун, би та нарт хэлнэ, үүнийг үгүйсгэгч хэн боловч худалч мөн чөтгөрийн хүүхэд болой.

Wo unto such an one, for he is not prepared, and the time is at hand that he must repent or he cannot be saved!

Yea, even wo unto all ye workers of iniquity; repent, repent, for the Lord God hath spoken it!

Behold, he sendeth an invitation unto all men, for the arms of mercy are extended towards them, and he saith: Repent, and I will receive you.

Yea, he saith: Come unto me and ye shall partake of the fruit of the tree of life; yea, ye shall eat and drink of the bread and the waters of life freely;

Yea, come unto me and bring forth works of righteousness, and ye shall not be hewn down and cast into the fire—

For behold, the time is at hand that whosoever bringeth forth not good fruit, or whosoever doeth not the works of righteousness, the same have cause to wail and mourn.

O ye workers of iniquity; ye that are puffed up in the vain things of the world, ye that have professed to have known the ways of righteousness nevertheless have gone astray, as sheep having no shepherd, notwithstanding a shepherd hath called after you and is still calling after you, but ye will not hearken unto his voice!

Behold, I say unto you, that the good shepherd doth call you; yea, and in his own name he doth call you, which is the name of Christ; and if ye will not hearken unto the voice of the good shepherd, to the name by which ye are called, behold, ye are not the sheep of the good shepherd.

And now if ye are not the sheep of the good shepherd, of what fold are ye? Behold, I say unto you, that the devil is your shepherd, and ye are of his fold; and now, who can deny this? Behold, I say unto you, whosoever denieth this is a liar and a child of the devil.

40 Учир нь сайн бүхэн Бурханаас ирдэг, мөн хилэнцэг болох юу боловч чөтгөрөөс ирдгийг би та нарт хэлнэ.

41 Тиймийн тул, хэрэв хүмүүн нь сайн ажлуудыг авчирваас тэрээр сайн хоньчны дуу хоолойг сонсож, мөн тэрээр түүнийг дагадаг; харин хилэнцэт үйлүүдийг авчрах хэн боловч, мөнхүү тэр нь чөтгөрийн хүүхэд болдог, учир нь тэрээр түүний дуу хоолойг сонсож, мөн түүнийг дагадаг.

42 Мөн үүнийг үйлдэгч хэн боловч шан хөлсөө түүнээс хүлээн авах ёстой; тиймийн тул, бүх сайн үйлүүдийн хувьд үхмэл байдаг учир тэрээр зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд хөлсөндөө үхлийг хүлээн авдаг, бөлгөө.

43 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар намайг сонсоосой хэмээнэ би, учир нь би бодгалийнхаа эрч хүчээр ярьж байна; учир нь болгоогтун, та нар алдах боломжгүйгээр би та нарт тодорхой ярьсан, өөрөөр хэлбэл Бурханы зарлигуудын дагуу ярьсан.

44 Учир нь би энэ маягаар, Христ Есүс дэх тэр Бурханы ариун жаягийн дагуу ярихаар дуудагдсан; тийм ээ, би босч мөн энэ хүмүүст ирэх тэр зүйлүүдийн талаар бидний эцэг өвгөдөөр яригдсан тэр зүйлийг гэрчлэхээр зарлигдуулсан юм.

45 Мөн энэ нь бүгд биш. Би эдгээр зүйлүүдийн тухай өөрөө мэддэг хэмээн та нар бодохгүй байна гэж үү? Болгоогтун, миний ярьсан эдгээр зүйлүүд үнэнийг би мэднэ хэмээн би та нарт гэрчилж байна. Мөн би тэдгээрийн гарцаагүйг яахан мэдэх билээ хэмээн та нар бодож байна уу

46 Болгоогтун, би та нарт хэлнэ тэдгээр нь Бурханы Ариун Сүнсээр надад мэдүүлэгдсэн билээ. Болгоогтун, би өөрөө эдгээр зүйлийг мэдэж болохын тулд олон хоног мацаг барьж бас залбирсан. Мөн эдүгээ би өөрөө тэдгээр нь үнэнийг мэднэ; учир нь Их Эзэн Бурхан өөрийн Ариун Сүнсээр надад тэдгээрийг үзүүлсэн юм; мөн энэ нь надад байгаа тэрхүү илчлэлтийн суу билэг бөлгөө.

47 Мөн үүнээс гадна, энэ нь тийн надад илчлэгдсэнийг, бидний эцэг өвгөдөөр яригдсан тэрхүү үгс үнэн гэдгийг, бүр надад буй бошиглолын суу билгийн дагуу, түүнчлэн Бурханы Сүнсний илэрхийлэлтээр гэдгийг би та нарт хэлнэ.

For I say unto you that whatsoever is good cometh from God, and whatsoever is evil cometh from the devil.

Therefore, if a man bringeth forth good works he hearkeneth unto the voice of the good shepherd, and he doth follow him; but whosoever bringeth forth evil works, the same becometh a child of the devil, for he hearkeneth unto his voice, and doth follow him.

And whosoever doeth this must receive his wages of him; therefore, for his wages he receiveth death, as to things pertaining unto righteousness, being dead unto all good works.

And now, my brethren, I would that ye should hear me, for I speak in the energy of my soul; for behold, I have spoken unto you plainly that ye cannot err, or have spoken according to the commandments of God.

For I am called to speak after this manner, according to the holy order of God, which is in Christ Jesus; yea, I am commanded to stand and testify unto this people the things which have been spoken by our fathers concerning the things which are to come.

And this is not all. Do ye not suppose that I know of these things myself? Behold, I testify unto you that I do know that these things whereof I have spoken are true. And how do ye suppose that I know of their surety?

Behold, I say unto you they are made known unto me by the Holy Spirit of God. Behold, I have fasted and prayed many days that I might know these things of myself. And now I do know of myself that they are true; for the Lord God hath made them manifest unto me by his Holy Spirit; and this is the spirit of revelation which is in me.

And moreover, I say unto you that it has thus been revealed unto me, that the words which have been spoken by our fathers are true, even so according to the spirit of prophecy which is in me, which is also by the manifestation of the Spirit of God.

48 Би та нарт хэлнэ, та нарт миний хэлэх юу боловч, ирэх тэрний тухайд тэр бүгд үнэн гэдгийг би өөрөө мэднэ; мөн би та нарт хэлнэ, Есүс Христ, тийм ээ, Хүү, Эцэгийн Төрсөн Ганц, ач ивээл, нигүүлсэл, мөн үнэнээр дүүрэн тэрбээр ирэх болно гэдгийг мэднэ буюу. Мөн болгоогтун, дэлхийн нүглүүдийг, тийм ээ, түүний нэрэнд гуйвшгүйгээр итгэх хүн бүрийн нүглийг зайлуулан авахаар ирэх нь тэр бөлгөө.

49 Мөн эдүгээ энэ бол, тийм ээ, хайрт ах дүүстээ номлохоор, тийм ээ, энэ нутагт орших хүн бүрд; тийм ээ, настай болон залуу аль алинд нь, боол болон чөлөөт аль алинд нь бүгдэд номлохоор; тийм ээ, би та нарт хэлнэ, настан, мөн түүнчлэн дунд насныханд, мөн өсөх залуу үеийнхэнд, тийм ээ, тэд наманчилж мөн дахин төрөх ёстой хэмээн тэдэнд тунхаглахаар үүний дагуу дуудагдсан тэрхүү жаяг гэдгийг би та нарт хэлье.

50 Тийм ээ: Наманчлагтун, газар дэлхийн бүх хязгаарууд та нар, учир нь тэнгэрийн хаант улс удахгүй ирнэ; тийм ээ, Бурханы Хүү өөрийн алдар суу, чадал, сүр жавхлан, хүч мөн эрх мэдэлтэйгээр ирэх болно хэмээн Сүнс хэлдэг. Тийм ээ, хайрт ах дүүс минь, би та нарт хэлнэ: Бүх газар дэлхийн Хааны алдар сууг болгоогтун; мөн түүнчлэн тэнгэрийн Хаан тун удахгүй хүмүүний бүх үрсийн дунд гэрэлтэх болно хэмээн Сүнс хэлдэг.

51 Мөн түүнчлэн Сүнс надад хэлэв, тийм ээ, надад хүчит дуугаар хашгирч өгүүлсэн нь: Явагтун мөн энэ хүмүүст хэл—Наманчлагтун, учир нь та нар наманчлахгүй аваас та нар тэнгэрийн хаант улсыг өвлөж яавч чадахгүй.

52 Мөн үүнчлэн би та нарт хэлнэ: Болгоогтун, модны ёзоорт сүх тавигдсан; тиймийн тул сайн үр жимс авчирдаггүй мод бүхэн цавчигдаж мөн галд хаягдах болно, тийм ээ, шатаж үл дуусах тэр галд, бүр унтраагдашгүй галд хэмээн Сүнс хэлдэг. Болгоогтун, мөн санагтун, Ариун Нэгэн үүнийг ярьсан бөлгөө.

I say unto you, that I know of myself that whatsoever I shall say unto you, concerning that which is to come, is true; and I say unto you, that I know that Jesus Christ shall come, yea, the Son, the Only Begotten of the Father, full of grace, and mercy, and truth. And behold, it is he that cometh to take away the sins of the world, yea, the sins of every man who steadfastly believeth on his name.

And now I say unto you that this is the order after which I am called, yea, to preach unto my beloved brethren, yea, and every one that dwelleth in the land; yea, to preach unto all, both old and young, both bond and free; yea, I say unto you the aged, and also the middle aged, and the rising generation; yea, to cry unto them that they must repent and be born again.

Yea, thus saith the Spirit: Repent, all ye ends of the earth, for the kingdom of heaven is soon at hand; yea, the Son of God cometh in his glory, in his might, majesty, power, and dominion. Yea, my beloved brethren, I say unto you, that the Spirit saith: Behold the glory of the King of all the earth; and also the King of heaven shall very soon shine forth among all the children of men.

And also the Spirit saith unto me, yea, crieth unto me with a mighty voice, saying: Go forth and say unto this people—Repent, for except ye repent ye can in nowise inherit the kingdom of heaven.

And again I say unto you, the Spirit saith: Behold, the ax is laid at the root of the tree; therefore every tree that bringeth not forth good fruit shall be hewn down and cast into the fire, yea, a fire which cannot be consumed, even an unquenchable fire. Behold, and remember, the Holy One hath spoken it.

- 53 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, би та нарт хэлнэ, та нар эдгээр хэлэгдсэнийг сөрж чадна гэж үү; тийм ээ, та нар эдгээр зүйлийг хойш тавьж, мөн Ариун Нэгэнийг хөл доороо дэвсэлж чадна гэж үү; тийм ээ, та нар зүрх сэтгэл дэх бардамналдаа хөөрч чадна гэж үү; тийм ээ, та нар цаашид үнэт хувцас хунар өмсөж мөн зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр, баялгууд дээрээ тавьсаар л байх гэж үү
- 54 Тийм ээ, та нар цаашид ч өөрсдийгөө нэг нь нөгөөгөөс илүү дээр хэмээн бодсоор л байх уу; тийм ээ, өөрсдийгөө даруусган мөн түүгээр тэд энэ сүмд авчрагдсан Бурханы ариун жаягийн дагуу алхалж, Ариун Сүнсээр ариусгагдаж, мөн наманчлалд нийцэх үйлүүдийг хийх ах дүүсээ та нар хавчин гадуурхсаар л байх уу—
- 55 Тийм ээ, мөн та нар ядууст хийгээд гачигдагсдад араа харуулан эргэж, тэднээс хөрөнгөө харамласаар л байх гэж үү
- 56 Мөн эцэст нь, ёс бус байдалдаа үлдэх та нар бүгд, эдгээр нь хурдхан наманчлахгүй аваас тас цавчигдаж мөн галд хаягдах тэдгээр юм гэдгийг би та нарт хэлье.
- 57 Мөн эдүгээ би та нарт хэлнэ, сайн хоньчны дуу хоолойг дагахыг хүсэх та нар бүгд, ёс бусыг үйлдэгчдийн дундаас гарч ирцгээ, мөн та нар тусдаа байгтун, мөн тэдний цэвэр бус зүйлүүдэд бүү хүрэгтүн; мөн болгоогтун, тэдний нэрс арилгагдах болно, ёс бусыг үйлдэгчдийн нэрс зөв шударгыг үйлдэгчдийн нэрсийн дунд тоологдохгүйн тулд, Бурханы үг гүйцэлдэж болохын тулд бөлгөө: Ёс бусыг үйлдэгчдийн нэрс миний хүмүүсийн нэрстэй холилдохгүй байх болно хэмээн хэлсэнчлэнгээр буюу;
- 58 Учир нь зөв шударгыг үйлдэгчдийн нэрс амьдралын номонд бичигдэх болно, мөн би тэдэнд өөрийн баруун гар дахь өвийг хайрлах болно. Мөн эдүгээ, ах дүүс минь, үүний эсрэг хэлэх юу та нарт буй билээ? Би та нарт хэлнэ, хэрэв та нар үүний эсрэг ярих аваас, тэр нь хамаагүй, учир нь Бурханы үг гүйцэлдэх ёстой.

And now my beloved brethren, I say unto you, can ye withstand these sayings; yea, can ye lay aside these things, and trample the Holy One under your feet; yea, can ye be puffed up in the pride of your hearts; yea, will ye still persist in the wearing of costly apparel and setting your hearts upon the vain things of the world, upon your riches?

Yea, will ye persist in supposing that ye are better one than another; yea, will ye persist in the persecution of your brethren, who humble themselves and do walk after the holy order of God, wherewith they have been brought into this church, having been sanctified by the Holy Spirit, and they do bring forth works which are meet for repentance—

Yea, and will you persist in turning your backs upon the poor, and the needy, and in withholding your substance from them?

And finally, all ye that will persist in your wickedness, I say unto you that these are they who shall be hewn down and cast into the fire except they speedily repent.

And now I say unto you, all you that are desirous to follow the voice of the good shepherd, come ye out from the wicked, and be ye separate, and touch not their unclean things; and behold, their names shall be blotted out, that the names of the wicked shall not be numbered among the names of the righteous, that the word of God may be fulfilled, which saith: The names of the wicked shall not be mingled with the names of my people;

For the names of the righteous shall be written in the book of life, and unto them will I grant an inheritance at my right hand. And now, my brethren, what have ye to say against this? I say unto you, if ye speak against it, it matters not, for the word of God must be fulfilled.



59 Учир нь та нарын дунд чононууд орж мөн сүргийг нь цөлмөхгүйн тулд олон хоньтой ч тэднийгээ хариулдаггүй ямар хоньчин байх билээ? Мөн болгоогтун, хэрэв чоно сүрэгт нь орвол тэрээр түүнийг хөөхгүй гэж үү? Тийм ээ, мөн эцэст нь хэрэв тэр чадвал, тэрээр түүнийг устгах болно.

60 Мөн эдүгээ сайн хоньчин та нарын араас дууддагийг би та нарт хэлнэ; мөн хэрэв та нар түүний дуу хоолойг сонсвол тэрээр та нарыг сүрэгтээ авчрах болно мөн та нар түүний хонь бигээ; мөн та нар устгаглахгүй байж болохын тулд та нар өөрсдийнхөө дунд араатан чоно орохыг үл зөвшөөр хэмээн тэрээр та нарт зарлигласан билээ.

61 Мөн эдүгээ би, Алма, надад зарлигласан түүний хэлээр, та нарт миний ярьсан үгсийг мөрдөхийг та нарт зарлиглаж байна.

62 Сүмд харьяалагдах та нарт би зарлигийн замаар ярина; мөн сүмд харьяалагдаагүй тэдэнд би урилгын замаар ярина, хэлрүүн: Та нар түүнчлэн амьдралын модны жимснээс хүртэгсэд байж болохын тулд ирэгтүн мөн наманчлалд баптисм хүртэгтүн.

For what shepherd is there among you having many sheep doth not watch over them, that the wolves enter not and devour his flock? And behold, if a wolf enter his flock doth he not drive him out? Yea, and at the last, if he can, he will destroy him.

And now I say unto you that the good shepherd doth call after you; and if you will hearken unto his voice he will bring you into his fold, and ye are his sheep; and he commandeth you that ye suffer no ravenous wolf to enter among you, that ye may not be destroyed.

And now I, Alma, do command you in the language of him who hath commanded me, that ye observe to do the words which I have spoken unto you.

I speak by way of command unto you that belong to the church; and unto those who do not belong to the church I speak by way of invitation, saying: Come and be baptized unto repentance, that ye also may be partakers of the fruit of the tree of life.

## Алма 6

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма Зарахемлагийн хотод байгуулагдсан, сүмийн хүмүүст ярихаа төгсгөл болгосны дараа, тэрээр Бурханы жаягийн дагуу гараа тавин, сүмийн дээр тэргүүлэх мөн хянах санваартнууд хийгээд ахлагчдыг томилов.
- 2 Мөнхүү улиран тохиох дор сүмд харъяалагдаагүй, нүглээ наманчилсан болгон нь, наманчлалд баптисм хүртэж, мөн сүмд хүлээн зөвшөөрөгдөв.
- 3 Мөн түүнчлэн улиран тохиох дор сүмд харъяалагдаж байсан ч өөрсдийн ёс бусыг наманчилж мөн Бурханы өмнө өөрсдийгөө даруусгаагүй хэн боловч—зүрх сэтгэл дэх бардамналдаа хөөрсөн тэднийг би хэлж байна—мөнхүү тэд нь гологдож, мөн зөв шударгыг үйлдэгсдийн дунд тоологдохгүйн тулд тэдний нэрс арилгагдсан бөлгөө.
- 4 Мөн тэд тийн Зарахемлагийн хотод сүмийн жаягийг үндэслэж эхлэв.
- 5 Эдүгээ Бурханы үг бүгдэд чөлөөтэй тул Бурханы үгийг сонсохоор хамтран чуулах хэний ч боломж булаагдаагүйг та нар ойлгоосой хэмээнэ би.
- 6 Гэсэн хэдий ч Бурханы хүүхдүүд ойр ойрхон нэгдэн цугларцгааж, мөн Бурханыг мэдэхгүй тэдний бодгалиудын аз жаргалын төлөө мацаг барих болон хүчирхэг залбиралд нэгдэхээр зарлигдуулсан билээ.
- 7 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр зохицуулалтыг хийгээд тэрээр тэднээс салж одлоо, тийм ээ Зарахемлагийн хотод байсан тэр сүмээс, мөн Сидон голын зүүнтээ гарч, Гидеоны хөндийд очлоо, тэнд Нихорын гараар илдэнд хөнөөгдсөн тэр хүний нэрээр, Гидеон гэж нэрлэгдсэн тэр хөндийд, Гидеоны хот гэж нэрлэгдсэн нэг хот баригдсан байсны улмаас буюу.
- 8 Мөн Алма явж мөн эцэг өвгөдөөрөө яригдсан тэрхүү үгийн үнэн гэсэн илчлэлтийн дагуу, мөн нүглүүдээс нь өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр ирэх Бурханы Хүү, Есүс Христийн талаарх гэрчлэлийн дагуу, өөрт нь байх тэрхүү бошиглолын суу билгийн дагуу, мөн өөрийн дуудагдсан тэр ариун жаягийн дагуу Бурханы үгийг Гидеоны хөндийд байгуулагдсан сүмд тунхаглаж эхлэв. Мөн тийн бичигдсэн болой. Амен.

## Alma 6

And now it came to pass that after Alma had made an end of speaking unto the people of the church, which was established in the city of Zarahemla, he ordained priests and elders, by laying on his hands according to the order of God, to preside and watch over the church.

And it came to pass that whosoever did not belong to the church who repented of their sins were baptized unto repentance, and were received into the church.

And it also came to pass that whosoever did belong to the church that did not repent of their wickedness and humble themselves before God—I mean those who were lifted up in the pride of their hearts—the same were rejected, and their names were blotted out, that their names were not numbered among those of the righteous.

And thus they began to establish the order of the church in the city of Zarahemla.

Now I would that ye should understand that the word of God was liberal unto all, that none were deprived of the privilege of assembling themselves together to hear the word of God.

Nevertheless the children of God were commanded that they should gather themselves together oft, and join in fasting and mighty prayer in behalf of the welfare of the souls of those who knew not God.

And now it came to pass that when Alma had made these regulations he departed from them, yea, from the church which was in the city of Zarahemla, and went over upon the east of the river Sidon, into the valley of Gideon, there having been a city built, which was called the city of Gideon, which was in the valley that was called Gideon, being called after the man who was slain by the hand of Nehor with the sword.

And Alma went and began to declare the word of God unto the church which was established in the valley of Gideon, according to the revelation of the truth of the word which had been spoken by his fathers, and according to the spirit of prophecy which was in him, according to the testimony of Jesus Christ, the Son of God, who should come to redeem his people from their sins, and the holy order by which he was called. And thus it is written. Amen.

*Гидеон дахь хүмүүст түүний хүргэсэн Алмагийн тэр үгс, түүний өөрийнх нь цэдгийн дагуу оршвой.*

## Алма 7

- 1 Болгоогтун хайрт ах дүүс минь, би та нар дээр ирэх боломжтой болсны учир, тиймийн тул би өөрийн хэлээр та нарт ярихыг оролдъё; тийм ээ, өөрийн амаар, би шүүгчийн суудалд бүрэн баригдаж, би та нарт ирж чадахааргүй их ажилтай байсан учир, энэ бол би анх удаа та нарт хандан өөрийн амны үгсээр ярьж байгаагийн учир буюу.
- 2 Мөн хэрэв шүүгчийн суудал миний оронд засаглах өөр нэгэнд өгөгдөөгүй байсан бол бүр энэ цагт ч гэсэн би ирж чадахгүй байх сан; мөн Их Эзэн их нигүүлслээр намайг та нар дээр ирэхийг минь зөвшөөрсөн билээ.
- 3 Мөн болгоогтун, та нар өөрсдийгөө Бурханы өмнө даруусгаг, мөн та нар түүний ач ивээлийг гуйсаар л буйг олж мэдэх юм сан, би та нарыг түүний өмнө буруугүй байхыг олж мэдэх юм сан, би та нарыг Зарахемла дахь бидний ах дүүсийн адил хүнд байдалд ороогүй байгааг олж мэдэх юм сан гэсэн агуу их найдлага мөн ихээхэн хүсэлтэйгээр ирсэн билээ би.
- 4 Гэвч Бурханы нэр алдаршиг, учир нь тэрээр надад мэдүүлж өгсөн билээ, тийм ээ, тэд дахин түүний зөвшударгын замд оруулагдсаныг нь мэдүүлэн үлэмж агуу баяслыг надад өгсөн билээ.
- 5 Мөн надад орших Бурханы Сүнсний дагуу, би түүнчлэн та нарын төлөө баясах болно гэдэгт би найдаж байна; гэсэн хэдий ч та нарын төлөө баясах миний баясал Зарахемла дахь ах дүүсийн төлөө надад байсан шиг тийм их зүдрэлүүд мөн харууслыг туулснаас ирээсэй хэмээн би хүсэхгүй байна, учир нь болгоогтун, тэдний төлөө миний баясал нь их зүдрэл мөн харууслыг туулсны дараа ирсэн бөлгөө.

*The words of Alma which he delivered to the people in Gideon, according to his own record.*

## Alma 7

Behold my beloved brethren, seeing that I have been permitted to come unto you, therefore I attempt to address you in my language; yea, by my own mouth, seeing that it is the first time that I have spoken unto you by the words of my mouth, I having been wholly confined to the judgment-seat, having had much business that I could not come unto you.

And even I could not have come now at this time were it not that the judgment-seat hath been given to another, to reign in my stead; and the Lord in much mercy hath granted that I should come unto you.

And behold, I have come having great hopes and much desire that I should find that ye had humbled yourselves before God, and that ye had continued in the supplicating of his grace, that I should find that ye were blameless before him, that I should find that ye were not in the awful dilemma that our brethren were in at Zarahemla.

But blessed be the name of God, that he hath given me to know, yea, hath given unto me the exceedingly great joy of knowing that they are established again in the way of his righteousness.

And I trust, according to the Spirit of God which is in me, that I shall also have joy over you; nevertheless I do not desire that my joy over you should come by the cause of so much afflictions and sorrow which I have had for the brethren at Zarahemla, for behold, my joy cometh over them after wading through much affliction and sorrow.

- 6 Гэвч болгоогтун, би та нарыг өөрсдийн ах дүүсийн адил тийм ч их итгэлгүй байдалд ороогүй байх хэмээн найдаж байна; би та нарыг зүрх сэтгэлийнхээ бардамналд хөөрөөгүй хэмээн найдаж байна; тийм ээ, би та нарыг зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр мөн баялгууд дээр тавиагүй хэмээн найдаж байна; тийм ээ, би та нарыг хиймэл шүтээн шүтдэггүй, харин үнэн бөгөөд амьд Бурханыг шүтэж, мөн хойшид ирэх нүглүүдийнхээ ангижралыг үүрдийн итгэлтэйгээр харуулдан хүлээсээр буй гэдэгт найдаж байна би.
- 7 Учир нь болгоогтун, би ирэх олон зүйл буйг та нарт хэлнэ; мөн болгоогтун, тэд бүгдээс илүү чухал нэгэн зүйл буй—учир нь болгоогтун, Гэтэлгэгч өөрийн хүмүүсийн дунд ирж мөн амьдрах тэрхүү цаг тийм ч холгүй болжээ.
- 8 Болгоогтун, тэрээр өөрийн зуурдын асарт орших цагтаа бидний дунд ирэх болно гэж би хэлээгүй; учир нь болгоогтун, энэ нь нөхцөл байхыг Сүнс надад хэлсэнгүй. Эдүгээ энэ зүйлийн хувьд би мэдэхгүй; гэвч энэ зэргийг, Их Эзэн Бурхан өөрийн үгийн дагуу тэр бүх зүйлийг хийх хүчтэйг би мэднэ.
- 9 Гэвч болгоогтун, Сүнс надад энэ зэргийг хэлж, өгүүлсэн нь: Энэ хүмүүст хашгирч, хэлэгтүн—Наманчлагтун та нар, мөн Их Эзэний замыг бэлтгэ, мөн шулуун болох түүний замуудаар алхагтун; учир нь болгоогтун тэнгэрийн хаант улс ойртож байна, мөн Бурханы Хүү дэлхийн гадаргуу дээр ирэх болно.
- 10 Мөн болгоогтун, тэр бидний эцэг өвгөдийн нутаг болох тэр Иерусалимд, Мариагаас төрөх болно, тэр нь онгон бүсгүй, Ариун Сүнсний хүчээр бүрхэгдэж мөн хөл хүнд болгогдож, мөн хүү төрүүлэх, тийм ээ, бүр Бурханы Хүүг тээгч болж сонгогдсон мөн хонгорхон нэгэн байх болно.
- 11 Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө.

But behold, I trust that ye are not in a state of so much unbelief as were your brethren; I trust that ye are not lifted up in the pride of your hearts; yea, I trust that ye have not set your hearts upon riches and the vain things of the world; yea, I trust that you do not worship idols, but that ye do worship the true and the living God, and that ye look forward for the remission of your sins, with an everlasting faith, which is to come.

For behold, I say unto you there be many things to come; and behold, there is one thing which is of more importance than they all—for behold, the time is not far distant that the Redeemer liveth and cometh among his people.

Behold, I do not say that he will come among us at the time of his dwelling in his mortal tabernacle; for behold, the Spirit hath not said unto me that this should be the case. Now as to this thing I do not know; but this much I do know, that the Lord God hath power to do all things which are according to his word.

But behold, the Spirit hath said this much unto me, saying: Cry unto this people, saying—Repent ye, and prepare the way of the Lord, and walk in his paths, which are straight; for behold, the kingdom of heaven is at hand, and the Son of God cometh upon the face of the earth.

And behold, he shall be born of Mary, at Jerusalem which is the land of our forefathers, she being a virgin, a precious and chosen vessel, who shall be overshadowed and conceive by the power of the Holy Ghost, and bring forth a son, yea, even the Son of God.

And he shall go forth, suffering pains and afflictions and temptations of every kind; and this that the word might be fulfilled which saith he will take upon him the pains and the sicknesses of his people.

12 Мөн тэрээр үхлийг өөр дээрээ авах болно, тэр өөрийнх нь хүмүүсийг хүлсэн тэрхүү үхлийн хүлээсийг тайлж болохын тулд бөлгөө; мөн түүний зүрх сэтгэл бие махбодийн дагуу нигүүлслээр дүүргэгдэж болохын тулд, тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авах болно.

13 Эдүгээ Сүнс бүх зүйлийг мэддэг; гэсэн хэдий ч Бурханы Хүү өөрийн хүмүүсийн нүглүүдийг өөр дээрээ авч болохын тулд, тэрээр өөрийн чөлөөлөлтийн хүчний дагуу тэдний зөрчлүүдийг арилгаж болохын тулд бие махбодийн дагуу зовох болно; мөн эдүгээ болгоогтун, надад буй гэрчлэл нь энэ болой.

14 Эдүгээ та нар наманчилж, мөн дахин төрөх ёстойг би та нарт хэлнэ; учир нь хэрэв та нар дахин төрөхгүй бол тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй хэмээн Сүнс хэлдэг; тиймийн тул ирэгтүн мөн наманчлалд баптисм хүртэгтүн, та нар нүглүүдээсээ угаагдаж болохын тулд, та нар дэлхийн нүглүүдийг зайлуулах, зөв шударга бус бүхнээс цэвэрлэж мөн аврах чадалтай, Бурханы Хурганд итгэлтэй байж болохын тулд бөлгөө.

15 Тийм ээ, ирэгтүн мөн бүү эмээ, мөн та нарыг амархан дайрах, та нарыг доош устгалд хүргэхээр хүлэх нүгэл бүрийг хойш тавь хэмээн би та нарт хэлнэ, тийм ээ, ирэгтүн мөн үйлдэгтүн, мөн Бурхандаа та нар нүглээ наманчилж мөн түүний зарлигуудыг дагахаар түүнтэй гэрээ хийхэд бэлэн байгаагаа үзүүлж, мөн үүнийгээ энэ өдөр баптисмын усанд орсноор түүнд гэрчлэгтүн.

16 Мөн үүнийг үйлдсэн мөн тэр цагаас Бурханы зарлигуудыг дагасан хэн боловч, мөнхүү тэр нь өөрт нь миний хэлснийг санах болно, надад гэрчлэх тэр Ариун Сүнсний гэрчлэлийн дагуу тэрээр мөнх амьдралыг авах болно тийм ээ, хэмээн түүнд миний хэлснийг тэрээр санах болно.

And he will take upon him death, that he may loose the bands of death which bind his people; and he will take upon him their infirmities, that his bowels may be filled with mercy, according to the flesh, that he may know according to the flesh how to succor his people according to their infirmities.

Now the Spirit knoweth all things; nevertheless the Son of God suffereth according to the flesh that he might take upon him the sins of his people, that he might blot out their transgressions according to the power of his deliverance; and now behold, this is the testimony which is in me.

Now I say unto you that ye must repent, and be born again; for the Spirit saith if ye are not born again ye cannot inherit the kingdom of heaven; therefore come and be baptized unto repentance, that ye may be washed from your sins, that ye may have faith on the Lamb of God, who taketh away the sins of the world, who is mighty to save and to cleanse from all unrighteousness.

Yea, I say unto you come and fear not, and lay aside every sin, which easily doth beset you, which doth bind you down to destruction, yea, come and go forth, and show unto your God that ye are willing to repent of your sins and enter into a covenant with him to keep his commandments, and witness it unto him this day by going into the waters of baptism.

And whosoever doeth this, and keepeth the commandments of God from thenceforth, the same will remember that I say unto him, yea, he will remember that I have said unto him, he shall have eternal life, according to the testimony of the Holy Spirit, which testifieth in me.

17 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, та нар эдгээр зүйлд итгэдэг үү? Болгоогтун, би та нарт хэлнэ, тийм ээ, та нарыг тэдгээрт итгэдгийг би мэднэ; мөн та нарын тэдгээрт итгэж буйг миний мэдсэн зам нь надад байх Сүнсний үзүүлснээр болой. Мөн эдүгээ миний ярьсан зүйлүүдийн талаар, тийм ээ, түүний талаарх та нарын итгэл хүчтэйн учир миний баясал агуу их болой.

18 Учир нь та нарыг ах дүүсийнхээ адил хүнд байдалд бүү байгаасай гэсэн их хүсэл надад байсныг би та нарт эхлэлээс хэлсэн лугаа адил, үүнчлэн миний хүсэл хангагдсаныг би олж мэдлээ.

19 Учир нь та нар зөв шударгын замууд дээр буйг би ухамсарлаж байна; та нар Бурханы хаант улс тийш удирдах зам дээр байгааг би ухамсарлаж байна; тийм ээ, та нар түүний замуудыг шулуутган үйлдэж буйг би ухамсарлав.

20 Тэрээр муруй тахир замуудаар алхаж чадахгүй нь түүний үгийн гэрчлэлээр та нарт мэдүүлэгдсэнийг би ухамсарлав; тэрээр өөрийн хэлснээс буцах нь ч үгүй; бас түүнд баруунаас солгой гар тийш, өөрөөр хэлбэл зөв болох түүнээс буруу болох түүний тийш эргэхийн сүүдэр ч үгүй байдаг; тиймийн тул, түүний замнал нэгэн мөнхийн эргэлт авай.

21 Мөн тэрээр ариун бус сүмүүдэд орших нь үгүй; бас Бурханы хаант улсад бузар эсвээс цэвэр бус нэг ч зүйл хүлээн авагдаж чадахгүй; тиймийн тул, бузар нэг нь өөрийн бузар байдалдаа үлдэх тэр цаг ирэх болно, тийм ээ, мөн энэ нь эцсийн өдөр байх болно гэдгийг би та нарт хэлье.

22 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, би та нарыг Бурханы өмнө хүлээх үүргийн тань мэдрэмжинд сэрээж болохын тулд, та нар түүний өмнө гэмгүйгээр алхаж болохын тулд, та нар хүлээн авсан түүнийхээ, та нар Бурханы ариун жаягийн дагуу алхаж болохын тулд би эдгээр зүйлийг та нарт хэлсэн бөлгөө.

23 Мөн эдүгээ би та нарыг даруухан, мөн хүлцэнгүй бас эелдэг байгаасай хэмээнэ; харьцахад амархан; тэсвэр мөн тэвчээрээр дүүрэн; бүх зүйлд биеэ барьж ханддаг; Бурханы зарлигуудыг дагахдаа цаг үргэлж шаргуу; сүнсний бас биеийн аль алинд нь хэрэгцээтэй зүйлийг юуг боловч гуйдаг; өөрсдийн хүлээн авдаг зүйлүүдэд юуны төлөө боловч Бурханд талархлаа үргэлж эргэн мэдүүлдэг байгаасай хэмээнэ.

And now my beloved brethren, do you believe these things? Behold, I say unto you, yea, I know that ye believe them; and the way that I know that ye believe them is by the manifestation of the Spirit which is in me. And now because your faith is strong concerning that, yea, concerning the things which I have spoken, great is my joy.

For as I said unto you from the beginning, that I had much desire that ye were not in the state of dilemma like your brethren, even so I have found that my desires have been gratified.

For I perceive that ye are in the paths of righteousness; I perceive that ye are in the path which leads to the kingdom of God; yea, I perceive that ye are making his paths straight.

I perceive that it has been made known unto you, by the testimony of his word, that he cannot walk in crooked paths; neither doth he vary from that which he hath said; neither hath he a shadow of turning from the right to the left, or from that which is right to that which is wrong; therefore, his course is one eternal round.

And he doth not dwell in unholy temples; neither can filthiness or anything which is unclean be received into the kingdom of God; therefore I say unto you the time shall come, yea, and it shall be at the last day, that he who is filthy shall remain in his filthiness.

And now my beloved brethren, I have said these things unto you that I might awaken you to a sense of your duty to God, that ye may walk blameless before him, that ye may walk after the holy order of God, after which ye have been received.

And now I would that ye should be humble, and be submissive and gentle; easy to be entreated; full of patience and long-suffering; being temperate in all things; being diligent in keeping the commandments of God at all times; asking for whatsoever things ye stand in need, both spiritual and temporal; always returning thanks unto God for whatsoever things ye do receive.

24 Мөн та нар итгэл, найдвар мөн энэрлийг агуулж бай, тэгвэл та нар сайн үйлсээр үргэлж бялхах болно.

25 Мөн та нарын өмсгөлийг толбогүй байлгаж, мөн өөрсдийн тань өмсгөлүүд бүр тэдний өмсгөлүүд мэт толбогүй учир, та нар эцсийн өдөр Абрахам, Исаак, мөн Иаков болон дэлхийн эхлэлээс байсан бүх ариун бошиглогчидтой хамт тэнгэрийн хаант улсад ахин гарахгүйгээр хамт суухаар хүргэгдэж болохын тулд Их Эзэн та нарыг адислаг.

26 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, надад гэрчлэх Сүнсний дагуу би эдгээр үгсийг та нарт ярилаа; мөн миний үгэнд хандсан та нарын үлэмжийн хичээнгүй байдал хийгээд анхаарлын учир бодгаль минь үлэмж баяснам.

27 Мөн эдүгээ, та нарын дээр, мөн танай гэр орон мөн газар нутгуудын дээр мөн та нарын бог бас бод мал, мөн та нарын эзэмшдэг бүхний дээр, та нарын эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн тань дээр, та нарын итгэл хийгээд сайн үйлсийн дагуу, Бурханы амар амгалан энэ цагаас хойш мөн үүрд оршиг. Мөн би ийн ярив. Амен.

And see that ye have faith, hope, and charity, and then ye will always abound in good works.

And may the Lord bless you, and keep your garments spotless, that ye may at last be brought to sit down with Abraham, Isaac, and Jacob, and the holy prophets who have been ever since the world began, having your garments spotless even as their garments are spotless, in the kingdom of heaven to go no more out.

And now my beloved brethren, I have spoken these words unto you according to the Spirit which testifieth in me; and my soul doth exceedingly rejoice, because of the exceeding diligence and heed which ye have given unto my word.

And now, may the peace of God rest upon you, and upon your houses and lands, and upon your flocks and herds, and all that you possess, your women and your children, according to your faith and good works, from this time forth and forever. And thus I have spoken. Amen.

## Алма 8

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор бичигдэж чадахааргүй олон зүйлийг Гидеоны хүмүүст зааж, тэрээр Зарахемлагийн нутагт урьд нь хийснийхээ адилаар сүмийн журмыг тогтоосны дараа Гидеоны нутгаас эргэж ирэв, тийм ээ, тэрээр өөрийн гүйцэтгэсэн хөдөлмөрөөс өөрийгөө амраахаар Зарахемла дахь гэртээ эргэж ирэв.
- 2 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын ес дэх он төгсгөв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын аравдугаар оны эхлэлд, Алма тэндээс одож мөн баруун зүгт аглаг буйдын захад, Сидон голын баруун тал дахь, Мелекийн нутаг тийш аянаа хөөв.
- 4 Мөн тэрээр өөрийн дуудагдсан байсан тэр Бурханы ариун жаягийн дагуу Мелек нутаг дахь хүмүүст зааж эхлэв; мөн тэрээр Мелекийн бүх нутаг даяар хүмүүст зааж эхлэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор аглаг буйдтай хиллэх нутгийн бүх хязгааруудаас хүмүүс түүн дээр ирэв. Мөн тэд бүх нутаг даяар баптисм хүртээв;
- 6 Түүнчлэн тэрээр Мелек дэх ажлаа дуусгаад тэндээс одож, мөн Мелек нутгийн умардыг зорин гурав хоног аялав; мөн тэр Аммонайха гэж нэрлэгдсэн хотод ирэв.
- 7 Эдүгээ өөрсдийн нутаг, мөн өөрсдийн хотууд, мөн өөрсдийн тосгод, тийм ээ, бүх жижиг тосгодоо ч анх тэдгээрийг эзэмшиж асан түүний нэрээр нэрлэх нь Нифайн хүмүүсийн заншил байв; мөн энэ нь Аммонайхагийн нутагт ч тийм байв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Алма Аммонайхагийн хотод ирээд тэрээр тэдэнд Бурханы үгийг номлож эхлэв.
- 9 Эдүгээ Аммонайхагийн хотын хүмүүсийн зүрх сэтгэлд Сатан агуу суурь эзэлсэн байв; тиймийн тул тэд Алмагийн үгсийг дуулсан нь үгүй.

## Alma 8

And now it came to pass that Alma returned from the land of Gideon, after having taught the people of Gideon many things which cannot be written, having established the order of the church, according as he had before done in the land of Zarahemla, yea, he returned to his own house at Zarahemla to rest himself from the labors which he had performed.

And thus ended the ninth year of the reign of the judges over the people of Nephi.

And it came to pass in the commencement of the tenth year of the reign of the judges over the people of Nephi, that Alma departed from thence and took his journey over into the land of Melek, on the west of the river Sidon, on the west by the borders of the wilderness.

And he began to teach the people in the land of Melek according to the holy order of God, by which he had been called; and he began to teach the people throughout all the land of Melek.

And it came to pass that the people came to him throughout all the borders of the land which was by the wilderness side. And they were baptized throughout all the land;

So that when he had finished his work at Melek he departed thence, and traveled three days' journey on the north of the land of Melek; and he came to a city which was called Ammonihah.

Now it was the custom of the people of Nephi to call their lands, and their cities, and their villages, yea, even all their small villages, after the name of him who first possessed them; and thus it was with the land of Ammonihah.

And it came to pass that when Alma had come to the city of Ammonihah he began to preach the word of God unto them.

Now Satan had gotten great hold upon the hearts of the people of the city of Ammonihah; therefore they would not hearken unto the words of Alma.



10 Гэсэн хэдий ч тэрээр Сүнсээ уг хотод байсан хүмүүсийн дээр юүлээсэй хэмээн Алма оюун санаагаар ихэд ажиллаж, тэмцсэн; тэрээр түүнчлэн тэд наманчлалд баптисм хүртэж болохыг зөвшөөрөөсэй хэмээн хүчит залбиралдаа Бурханы өмнө өөртэйгөө тэмцэлдсэн ажээ.

11 Гэсэн хэдий ч, тэд зүрх сэтгэлээ хатууруулж, түүнд хэлсэн нь: Болгоогтун, та бол Алма гэдгийг бид мэднэ; мөн та бол өөрийн уламжлалын дагуу уг нутгийн олон хэсгүүдэд өөрийн байгуулсан сүмийн дээрх дээд санваартан гэдгийг бид мэднэ; мөн бид танай сүмийнх бус, мөн бид тийм мунхаг уламжлалд итгэхгүй.

12 Мөн эдүгээ бид таны сүмийнх биш учраас та бидний дээр хүчгүйг тань бид мэднэ; мөн та шүүгчийн суудлыг Нифайхад дамжуулан өгсөн; тиймийн тул та бидний дээрх ерөнхий шүүгч биш.

13 Эдүгээ хүмүүс үүнийг хэлж, мөн түүний бүх үгсийг эсэргүүцэж, мөн түүнийг доромжлон, мөн түүний дээр нулимж, мөн түүнийг хотоосоо зайлуулсны дараа, тэрээр тэндээс одож мөн Аарон гэж нэрлэгдсэн хотын зүг аянаа хөөв.

14 Мөнхүү улиран тохиох дор Аммонайхагийн хотод байсан хүмүүсийн ёс бусын учир их бэрхшээл мөн сэтгэлийн тарчлалыг туулан, тэрээр харуусалдаа дарагдан цааш аялж явтал, улиран тохиох дор Алма тийн харуусалд дарагдан байтал, болгоогтун Их Эзэний нэгэн тэнгэр элч түүнд үзэгдэж, өгүүлсэн нь:

15 Адислагдсан болой та, Алма; тиймийн тул, тэргүүнээ өргө мөн баясагтун, учир нь танд баясах агуу шалтгаан буй; тодруулбал та түүнээс анхныхаа зарыг хүлээн авсан тэр цагаас Бурханы зарлигуудыг дагахад итгэлтэй байсан болой. Болгоогтун, үүнийг танд хүргэсэн нь би билээ.

16 Мөн болгоогтун, таныг Аммонайхагийн хотод эргэн очиж, мөн уг хотын хүмүүст дахин номло хэмээн танд зарлиглахаар илгээгдсэн болой би; тийм ээ, тэдэнд номлогтун. Тийм ээ, тэд наманчлахгүй аваас Их Эзэн Бурхан тэднийг устгах болно гэдгийг тэдэнд хэлэгтүн.

Nevertheless Alma labored much in the spirit, wrestling with God in mighty prayer, that he would pour out his Spirit upon the people who were in the city; that he would also grant that he might baptize them unto repentance.

Nevertheless, they hardened their hearts, saying unto him: Behold, we know that thou art Alma; and we know that thou art high priest over the church which thou hast established in many parts of the land, according to your tradition; and we are not of thy church, and we do not believe in such foolish traditions.

And now we know that because we are not of thy church we know that thou hast no power over us; and thou hast delivered up the judgment-seat unto Nephiah; therefore thou art not the chief judge over us.

Now when the people had said this, and withstood all his words, and reviled him, and spit upon him, and caused that he should be cast out of their city, he departed thence and took his journey towards the city which was called Aaron.

And it came to pass that while he was journeying thither, being weighed down with sorrow, wading through much tribulation and anguish of soul, because of the wickedness of the people who were in the city of Ammonihah, it came to pass while Alma was thus weighed down with sorrow, behold an angel of the Lord appeared unto him, saying:

Blessed art thou, Alma; therefore, lift up thy head and rejoice, for thou hast great cause to rejoice; for thou hast been faithful in keeping the commandments of God from the time which thou receivedst thy first message from him. Behold, I am he that delivered it unto you.

And behold, I am sent to command thee that thou return to the city of Ammonihah, and preach again unto the people of the city; yea, preach unto them. Yea, say unto them, except they repent the Lord God will destroy them.

17 Учир нь болгоогтун, тэд таны хүмүүсийн эрх чөлөөг устгаж болохын тулд тэд энэ цагт бодолхийлнэ, (учир нь Их Эзэн ийн хэлдэг) энэ нь түүний өөрийнхөө хүмүүст өгсөн түүний тогтоолууд, мөн шүүлтүүд, мөн зарлигуудын эсрэг болох тэр болой.

18 Эдүгээ улиран тохиох дор Алма Их Эзэний тэнгэр элчээс түүний зарыг хүлээн авсныхаа дараа тэрээр Аммонайха нутгийн зүг хурдан эргэлээ. Мөн тэрээр уг хотод өөр нэг замаар, тийм ээ, Аммонайха хотын өмнөдөд байх замаар нэвтрэв бөлгөө.

19 Мөн тэрээр хотод орохдоо тэр өлсөж байв, мөн тэрээр нэгэн эрд хэлэв: Бурханы даруухан үйлчлэгчид та идэх юм өгөөч

20 Мөн сайхь эр түүнд хэлэв: Би бол нифай үндэстнийх, мөн та бол Бурханы ариун бошиглогч гэдгийг би мэднэ, учир нь тэнгэр элч: Та хүлээн авах болно хэмээн үзэгдлээр хэлсэн тэр хүн бол та болой. Тиймийн тул, надтай хамт гэрт минь оч мөн би тантай хүнсээ хуваая; мөн та надад болон миний гэрийнхэнд адислал байх болно.

21 Мөнхүү улиран тохиох дор мөнөөх хүн түүнийг гэртээ хүлээн авав; мөн тэр хүн Амюлек хэмээх нэртэй байв; мөн тэрээр талх, мах авчирч мөн Алмагийн өмнө тавив.

22 Мөнхүү улиран тохиох дор Алма талхыг идэж цадав; мөн тэрээр Амюлекийг мөн түүний гэрийнхнийг адислав, тэгээд тэрээр Бурханд талархал мэдүүлэв.

23 Мөн тэр идэж мөн цадсаныхаа дараа Амюлект хэлсэн нь: Би бол Алма, мөн уг нутаг даяарх Бурханы сүмийн дээрх дээд санваартан.

24 Мөн болгоогтун, би энэ бүх хүмүүсийн дунд, илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн дагуу, Бурханы үгийг номлохоор дуудагдсан; мөн би энэ нутагт байсан мөн тэд намайг хүлээж авахгүй байлаа, харин тэд намайг хөөж тэгээд би үүрд энэ нутагт араа харуулах дөхөв.

25 Гэвч болгоогтун, би дахин эргэж мөн энэ хүмүүст, тийм ээ, мөн тэдний алдсуудын талаар тэдний эсрэг гэрчлэхээр бошиглох ёстой хэмээн зарлиглуулав.

26 Мөн эдүгээ, Амюлек, та намайг хооллож мөн оруулсан учир адислагдсан билээ та; учир нь би олон хоног мацаг барьснаас би өлссөн байв.

For behold, they do study at this time that they may destroy the liberty of thy people, (for thus saith the Lord) which is contrary to the statutes, and judgments, and commandments which he has given unto his people.

Now it came to pass that after Alma had received his message from the angel of the Lord he returned speedily to the land of Ammonihah. And he entered the city by another way, yea, by the way which is on the south of the city of Ammonihah.

And as he entered the city he was an hungered, and he said to a man: Will ye give to an humble servant of God something to eat?

And the man said unto him: I am a Nephite, and I know that thou art a holy prophet of God, for thou art the man whom an angel said in a vision: Thou shalt receive. Therefore, go with me into my house and I will impart unto thee of my food; and I know that thou wilt be a blessing unto me and my house.

And it came to pass that the man received him into his house; and the man was called Amulek; and he brought forth bread and meat and set before Alma.

And it came to pass that Alma ate bread and was filled; and he blessed Amulek and his house, and he gave thanks unto God.

And after he had eaten and was filled he said unto Amulek: I am Alma, and am the high priest over the church of God throughout the land.

And behold, I have been called to preach the word of God among all this people, according to the spirit of revelation and prophecy; and I was in this land and they would not receive me, but they cast me out and I was about to set my back towards this land forever.

But behold, I have been commanded that I should turn again and prophesy unto this people, yea, and to testify against them concerning their iniquities.

And now, Amulek, because thou hast fed me and taken me in, thou art blessed; for I was an hungered, for I had fasted many days.

- 27 Мөн Алма хүмүүст номлож эхлэхийн өмнө тэрээр олон хоног Амюлектэй үлдэв.
- 28 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс алдсууддаа улам бүр лавширч байв.
- 29 Мөн үг Алмад ирж хэлрүүн: Явагтун; мөн түүнчлэн миний зарц Амюлект хэл, явж мөн энэ хүмүүст бошиглогтун, өгүүлсэн нь—Наманчлагтун та нар, учир нь Их Эзэн ийн хэлнэ, та нар наманчлахгүй аваас би энэ хүмүүст уур хилэнгээрээ зочлох болно; тийм ээ, мөн би догшин хилэнгээ холдуулах нь үгүй.
- 30 Мөн Алма, мөн түүнчлэн Амюлек, Бурханы үгсийг тэдэнд тунхаглахаар хүмүүсийн дунд одов; мөн тэд Ариун Сүнсээр дүүргэгдэв.
- 31 Мөн тэдэнд хүч өгөгдсөн байв, үүний хэрээр тэд гянданд хоригдох нь боломжгүй болсон аж; бас хэн нэгэн тэднийг алах боломжгүй байсан аж; гэсэн хэдий ч тэд хүлэгдэж мөн шоронд хаягдах хүртлээ өөрсдийн хүчийг хэрэглэсэнгүй. Эдүгээ, энэ нь Их Эзэн өөрийн хүчийг тэднээр үзүүлж болохын тулд хийгдсэн бөлгөө.
- 32 Мөнхүү улиран тохиох дор тэд одож мөн Их Эзэн тэдэнд өгсөн тэрхүү сүнс болоод хүчний дагуу хүмүүст номлож мөн бошиглож эхлэв.

And Alma tarried many days with Amulek before he began to preach unto the people.

And it came to pass that the people did wax more gross in their iniquities.

And the word came to Alma, saying: Go; and also say unto my servant Amulek, go forth and prophesy unto this people, saying—Repent ye, for thus saith the Lord, except ye repent I will visit this people in mine anger; yea, and I will not turn my fierce anger away.

And Alma went forth, and also Amulek, among the people, to declare the words of God unto them; and they were filled with the Holy Ghost.

And they had power given unto them, insomuch that they could not be confined in dungeons; neither was it possible that any man could slay them; nevertheless they did not exercise their power until they were bound in bands and cast into prison. Now, this was done that the Lord might show forth his power in them.

And it came to pass that they went forth and began to preach and to prophesy unto the people, according to the spirit and power which the Lord had given them.

*Аммонайхагийн нутагт байсан хүмүүст тунхагласан, Алмагийн үгс, мөн түүнчлэн Амюлекийн үгс оривой. Мөн түүнчлэн тэд шоронд хаягдаж, мөн тэдэнд байсан Бурханы тэрхүү гайхамшигт хүчээр чөлөөлөгдөв, Алмагийн цэдгийн дагуу оривой.*

## Алма 9

- 1 Мөн үүнчлэн, Алма, би, Амюлекийг авч мөн явж мөн дахин энэ хүмүүст өөрөөр хэлбэл Аммонайхагийн хотод байсан хүмүүст номлохыг Бурханаас зарлиг болгуулаад, улиран тохиох дор намайг тэдэнд номлож эхлэхэд, тэд надтай ийн маргаж эхлэв, өгүүлсэн нь:
  - 2 Та хэн билээ? Бид нэг хүний гэрчлэлд, тэр ч байтугай тэрээр бидэнд дэлхий сөнөх болно хэмээн номлож байхад итгэнэ хэмээн та бодно уу
  - 3 Эдүгээ тэд өөрсдийн ярьсан үгсээ ойлгосон нь үгүй; учир нь тэд дэлхий сөнөх болно гэдгийг мэдсэнгүй.
  - 4 Мөн тэд түүнчлэн хэлэв: Хэрэв та энэ агуу хот нэг өдрийн дотор устгагдах болно хэмээн бошигловч бид таны үгсэд итгэхгүй.
  - 5 Эдүгээ тэд Бурхан тийм гайхамшигт үйлүүдийг хийж чаддагийг мэдсэнгүй, учир нь тэд зүрх сэтгэл нь хатуу мөн зөрүүд хүмүүс байв.
  - 6 Мөн тэд хэлэв: Энэ хүмүүсийн дунд тийм агуу хийгээд гайхамшигт зүйлүүдийн үнэнийг тэдэнд тунхаглуулахаар нэг хүнээс илүүд эрх мэдэлтнийг үл илгээгч, Бурхан гэгч хэн бэ
  - 7 Мөн тэд надад гар хүрэхээр урагш дөхөв; гэвч болгоогтун, тэд тэгсэнгүй. Мөн би тэдэнд тунхаглахаар зоригтойгоор зогсов, тийм ээ, би тэдэнд зоригтойгоор гэрчилж хэлсэн нь:
    - 8 Болгоогтун, Ай ёс бус мөн тэрс үеийнхэн та нар, эцэг өвгөдийнхөө уламжлалыг та нар хэрхэн мартав; тийм ээ, та нар Бурханы зарлигуудыг хичнээн хурдан мартав аа.
    - 9 Бидний өвөг болох Лихай, Бурханы мутраар Иерусалимаас гарган авчрагдсаныг санахгүй байна уу? Та нар тэд бүгд аглаг буйд дундуур түүгээр удирдагдсаныг санахгүй байна уу та нар

*The words of Alma, and also the words of Amulek, which were declared unto the people who were in the land of Ammonihah. And also they are cast into prison, and delivered by the miraculous power of God which was in them, according to the record of Alma.*

## Alma 9

And again, I, Alma, having been commanded of God that I should take Amulek and go forth and preach again unto this people, or the people who were in the city of Ammonihah, it came to pass as I began to preach unto them, they began to contend with me, saying:

Who art thou? Suppose ye that we shall believe the testimony of one man, although he should preach unto us that the earth should pass away?

Now they understood not the words which they spake; for they knew not that the earth should pass away.

And they said also: We will not believe thy words if thou shouldst prophesy that this great city should be destroyed in one day.

Now they knew not that God could do such marvelous works, for they were a hard-hearted and a stiff-necked people.

And they said: Who is God, that sendeth no more authority than one man among this people, to declare unto them the truth of such great and marvelous things?

And they stood forth to lay their hands on me; but behold, they did not. And I stood with boldness to declare unto them, yea, I did boldly testify unto them, saying:

Behold, O ye wicked and perverse generation, how have ye forgotten the tradition of your fathers; yea, how soon ye have forgotten the commandments of God.

Do ye not remember that our father, Lehi, was brought out of Jerusalem by the hand of God? Do ye not remember that they were all led by him through the wilderness?

- 10 Мөн тэрээр хичнээн удаа бидний эцэг өвгөдийг дайснуудынх нь гараас чөлөөлж, мөн тэднийг бүр ах дүүсийнх нь гараар устгагдахаас хадгалан хамгаалсныг ийм хурдан мартсан гэж үү, та нар
- 11 Тийм ээ, мөн хэрэв түүний зүйрлэшгүй хүч, мөн түүний нигүүлсэл, мөн бидэнд хандах түүний тэсвэр байгаагүй сэн бол, бид цагийн энэ үеэс хамаагүй урьд гарах аргагүйгээр газрын гадаргуу дээрээс арчигдах байсан, мөн төгсгөлгүй зовлон мөн гаслангийн байдалд оноогдох нь болзошгүй ажгуу.
- 12 Болгоогтун, эдүгээ тэрээр наманчлахыг та нарт зарлиглаж байна хэмээн та нарт хэлж байна би; мөн та нар наманчлахгүй аваас та нар Бурханы хаант улсыг өвлөж чадах аргагүй болно. Гэвч болгоогтун, энэ нь бүгд биш—тэрээр та нарт наманчлахыг зарлигласан, эсвээс тэр та нарыг газрын гадаргуу дээрээс бүрмөсөн устгах болно; тийм ээ, тэрээр та нарт уур хилэндээ зочлох болно, мөн догшин хилэндээ тэр холдож зайлахгүй байх болно.
- 13 Болгоогтун, тэрээр Лихайд ярьж, хэлсэн нь: Та нар миний зарлигуудыг дагахын хэрээр, та нар уг нутагт дэгжих болно гэсэн үгсийг санахгүй байна уу? Мөн үүнчлэн: Та нар миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах болно гэсэн үг байдаг билээ.
- 14 Эдүгээ леменчүүд Бурханы зарлигуудыг дагаагүйн хэрээр, тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсаныг та нар санаасай хэмээнэ би. Эдүгээ Их Эзэний үг энэ зүйлд нотлогдож, мөн леменчүүд уг нутаг дахь зөрчлүүдийнхээ эхлэлээс л түүний дэргэдээс тусгаарлагдсаныг бид харж байна.
- 15 Гэсэн хэдий ч би та нарт хэлнэ, хэрэв та нар нүглүүддээ үлдвэл шүүлтийн өдөр тэд та нараас илүү тэвчиж болмоор байх болно, тийм ээ, мөн та нар наманчлахаас бусдаар бол, бүр энэ амьдралд ч тэд та нараас илүү тэвчиж болмоор байх болно.
- 16 Учир нь; тэднийг үл мэдэх байдалд байлгадаг тэдний эцэг өвгөдийнх нь уламжлалуудын учир леменчүүдэд зориулагдсан олон амлалт байдаг; тиймийн тул Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй хандаж мөн уг нутагт оршихыг нь уртасгах болно.

And have ye forgotten so soon how many times he delivered our fathers out of the hands of their enemies, and preserved them from being destroyed, even by the hands of their own brethren?

Yea, and if it had not been for his matchless power, and his mercy, and his long-suffering towards us, we should unavoidably have been cut off from the face of the earth long before this period of time, and perhaps been consigned to a state of endless misery and woe.

Behold, now I say unto you that he commandeth you to repent; and except ye repent, ye can in nowise inherit the kingdom of God. But behold, this is not all—he has commanded you to repent, or he will utterly destroy you from off the face of the earth; yea, he will visit you in his anger, and in his fierce anger he will not turn away.

Behold, do ye not remember the words which he spake unto Lehi, saying that: Inasmuch as ye shall keep my commandments, ye shall prosper in the land? And again it is said that: Inasmuch as ye will not keep my commandments ye shall be cut off from the presence of the Lord.

Now I would that ye should remember, that inasmuch as the Lamanites have not kept the commandments of God, they have been cut off from the presence of the Lord. Now we see that the word of the Lord has been verified in this thing, and the Lamanites have been cut off from his presence, from the beginning of their transgressions in the land.

Nevertheless I say unto you, that it shall be more tolerable for them in the day of judgment than for you, if ye remain in your sins, yea, and even more tolerable for them in this life than for you, except ye repent.

For there are many promises which are extended to the Lamanites; for it is because of the traditions of their fathers that caused them to remain in their state of ignorance; therefore the Lord will be merciful unto them and prolong their existence in the land.

17 Мөн эцэг өвгөдийнх уламжлалууд нь зөв бус гэдгийг мэдэхийн тулд, тэд түүний үгсэд итгүүлэхээр хэзээ нэгэн цагт авчрагдана; мөн тэдний олон нь аврагдах болно, учир нь Их Эзэн өөрийнх нь нэрийг дуудах тэд бүгдэд нигүүлсэнгүй хандах болно.

18 Гэвч болгоогтун, хэрэв та нар ёс бус байдалдаа хэвээр үлдвэл энэ нутаг дахь та нарын өдрүүд уртастагдах нь үгүй гэдгийг би та нарт хэлнэ, учир нь леменчүүд та нарын дээр илгээгдэх болно; мөн хэрэв та нар наманчлахгүй аваас тэд та нарын мэдээгүй үед чинь ирэх болно, мөн та нар бүрмөсөн устгагдах устгалаар зочлогдох болно; мөн энэ нь Их Эзэний догшин хилэнгийн дагуу байх болно.

19 Учир нь өөрийнх нь хүмүүсийг устгахыг, та нарыг алдастаа амьдрахыг тэр үл тэвих болно. Би та нарт хэлнэ, Үгүй; хэрэв тийм их гэрэл мөн тийм их мэдлэг Их Эзэн Бурханаас нь тэдэнд өгөгдсөний дараа, тэд нүгэлд мөн зөрчилд унах нь боломжтой аваас, тэрээр Нифайн хүмүүс гэж нэрлэгдсэн өөрийнх нь бүх хүмүүсийг леменчүүд устгахыг тэвчих нь дээр гэж үзэх болно;

20 Тийм ээ, Их Эзэний маш ихээр таалсан хүмүүс байсны дараа; тийм ээ, бусад бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүсээс илүүтэйгээр таалсны дараа; тэдний хүсэл, мөн тэдний итгэл, мөн залбирлуудынх нь дагуу байсан, байгаа, мөн байх тэдгээр бүх зүйл тэдэнд мэдүүлэгдсэний дараа буюу;

21 Бурханы Сүнсээр зочлогдсоны; тэнгэр элчүүдтэй ярилцаж, мөн Их Эзэний дуу хоолой өөрсдөд нь ярьсны дараа; мөн бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг, мөн түүнчлэн олон бэлэг, хэл хэлээр ярих бэлэг, номлох бэлэг, мөн Ариун Сүнсний бэлэг, мөн орчуулгын бэлгийг авсны дараа буюу;

22 Тийм ээ, Бурханаар Иерусалимын нутгаас Их Эзэний мутраар гаргагдан чөлөөлөгдсөний дараа; өлсгөлөнгөөс, мөн өвчнүүдээс, мөн бүх төрлийн зүйл бүрийн эмгэгүүдээс аврагдсаны дараа; мөн тэд устгагдаж болохгүйн учир, тулаанд хүчтэй болсны дараа; цагаас цагт дарангуйллаас гарган авчрагдаж, мөн эдүгээг хүртэл хамгаалагдаж мөн хадгалагдсаны дараа; мөн тэд бүх төрлийн зүйлүүдээр баян болтлоо дэгжээгдсэний дараа—

And at some period of time they will be brought to believe in his word, and to know of the incorrectness of the traditions of their fathers; and many of them will be saved, for the Lord will be merciful unto all who call on his name.

But behold, I say unto you that if ye persist in your wickedness that your days shall not be prolonged in the land, for the Lamanites shall be sent upon you; and if ye repent not they shall come in a time when you know not, and ye shall be visited with utter destruction; and it shall be according to the fierce anger of the Lord.

For he will not suffer you that ye shall live in your iniquities, to destroy his people. I say unto you, Nay; he would rather suffer that the Lamanites might destroy all his people who are called the people of Nephi, if it were possible that they could fall into sins and transgressions, after having had so much light and so much knowledge given unto them of the Lord their God;

Yea, after having been such a highly favored people of the Lord; yea, after having been favored above every other nation, kindred, tongue, or people; after having had all things made known unto them, according to their desires, and their faith, and prayers, of that which has been, and which is, and which is to come;

Having been visited by the Spirit of God; having conversed with angels, and having been spoken unto by the voice of the Lord; and having the spirit of prophecy, and the spirit of revelation, and also many gifts, the gift of speaking with tongues, and the gift of preaching, and the gift of the Holy Ghost, and the gift of translation;

Yea, and after having been delivered of God out of the land of Jerusalem, by the hand of the Lord; having been saved from famine, and from sickness, and all manner of diseases of every kind; and they having waxed strong in battle, that they might not be destroyed; having been brought out of bondage time after time, and having been kept and preserved until now; and they have been prospered until they are rich in all manner of things—

- 23 Мөн эдүгээ болгоогтун би та нарт хэлнэ, хэрэв ийм олон адислалыг Их Эзэний мутраас хүлээн авсан энэ хүмүүс, тэдэнд байх гэрэл мөн мэдлэгийн эсрэг зөрчил үйлдэх аваас, би та нарт хэлнэ хэрэв энэ байдал тохиовол, хэрэв тэд зөрчилд унах аваас, тэднийг бодвол леменчүүд хамаагүй илүү хүлцэж болохуйц байх болно.
- 24 Учир нь болгоогтун, Их Эзэний амлалтууд леменчүүдэд зориулагдсан юм, гэвч хэрэв та нар зөрчил үйлдвэл тэдгээр нь та нарт хүртээлгүй; учир нь хэрэв та нар түүнийг эсэргүүцвэл та нар газрын гадаргуу дээрээс бүрмөсөн устгагдах болно хэмээн Их Эзэн тодорхойгоор амлаж мөн чандлан тогтоосон бус уу
- 25 Мөн эдүгээ та нар устгагдахгүй байж болох энэхүү шалтгааны учир, Их Эзэн өөрийн хүмүүсээс олонд нь тэнгэр элчээ зочлуулахаар мөн ийн тунхаглуулахаар илгээсэн ажгуу; тэд явж мөн энэ хүмүүст хүчтэйгээр ийн хашгирах ёстой хэмээн, өгүүлсэн нь: Наманчлагтун та нар, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна;
- 26 Мөн үүнээс олон бус өдрийн дараа Бурханы Хүү алдар суундаа ирэх болно; мөн түүний алдар суу ач ивээл, тэгш эрх, мөн үнэнээр дүүрэн, тэвчээр, нигүүлсэл, мөн тэсвэрээр дүүрэн, өөрийн хүмүүсийн гуйлтыг сонсохдоо мөн тэдний залбирлуудыг хариулахдаа түргэн, Эцэгийн Төрсөн Ганцын алдар суу байх болно.
- 27 Мөн болгоогтун, тэрээр түүний нэрэнд итгэлтэйн дагуу наманчлалд баптисм хүртэх тэднийг гэтэлгэхээр ирэх болно.
- 28 Тиймийн тул, та нар Их Эзэний замыг бэлтгэцгээ, учир нь бүх хүмүүн өөрсдийн ажлын шагналыг хадан авах тэр цаг ойрхон байна, тэдгээр нь ямар байсны дагуу—хэрэв тэдгээр нь зөв шударга байсан бол тэд Есүс Христийн хүч мөн чөлөөлөлтийн дагуу, бодгальдаа авралыг хадан авах болно; мөн хэрэв тэдгээр нь хилэнцэт байсан бол тэд чөтгөрийн хүч мөн боолчлолын дагуу, бодгальдаа ялыг хадан авах болно.
- 29 Эдүгээ болгоогтун, энэ бол хүмүүст хашгирах тэнгэр элчийн дуу хоолой билээ.

And now behold I say unto you, that if this people, who have received so many blessings from the hand of the Lord, should transgress contrary to the light and knowledge which they do have, I say unto you that if this be the case, that if they should fall into transgression, it would be far more tolerable for the Lamanites than for them.

For behold, the promises of the Lord are extended to the Lamanites, but they are not unto you if ye transgress; for has not the Lord expressly promised and firmly decreed, that if ye will rebel against him that ye shall utterly be destroyed from off the face of the earth?

And now for this cause, that ye may not be destroyed, the Lord has sent his angel to visit many of his people, declaring unto them that they must go forth and cry mightily unto this people, saying: Repent ye, for the kingdom of heaven is nigh at hand;

And not many days hence the Son of God shall come in his glory; and his glory shall be the glory of the Only Begotten of the Father, full of grace, equity, and truth, full of patience, mercy, and long-suffering, quick to hear the cries of his people and to answer their prayers.

And behold, he cometh to redeem those who will be baptized unto repentance, through faith on his name.

Therefore, prepare ye the way of the Lord, for the time is at hand that all men shall reap a reward of their works, according to that which they have been—if they have been righteous they shall reap the salvation of their souls, according to the power and deliverance of Jesus Christ; and if they have been evil they shall reap the damnation of their souls, according to the power and captivity of the devil.

Now behold, this is the voice of the angel, crying unto the people.

30 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, учир нь та нар миний ах дүүс, мөн та нар хайрлагдвал зохино, мөн та нар наманчлалд нийцэх тэр үйлүүдийг авчирвал зохино, яагаад гэвэл та нарын зүрх сэтгэл Бурханы үгийн эсрэг дэндүү хатуурсан байв, мөн та нар төөрөлдсөн мөн унасан хүмүүс байсны учир болой.

31 Эдүгээ улиран тохиох дор би, Алма, эдгээр үгсийг ярихад, болгоогтун, хүмүүс надад хилэгнэж байсны учир би өөрсдөд нь тэд бол хатуу зүрх сэтгэлтэй мөн зөрүүд хүмүүс байсан хэмээн хэлсэн бөлгөө.

32 Мөн түүнчлэн би тэдэнд тэд бол төөрөлдсөн мөн унасан хүмүүс байсныг хэлсэн учир тэд надад уурлаж, мөн тэд намайг шоронд хаяж болохын тулд тэд надад гар хүрэхийг завдав.

33 Гэвч улиран тохиох дор Их Эзэн тэдэнд тэр цагт намайг барьж мөн намайг шоронд хийхийг зөвшөөрсөнгүй.

34 Мөнхүү улиран тохиох дор Амюлек явж мөн урагшлан зогсож, мөн түүнчлэн тэдэнд номлож эхлэв. Мөн эдүгээ Амюлекийн үгс бүгд бичигдсэнгүй, гэсэн хэдий ч түүний үгсийн нэг хэсэг нь энэ номонд бичиглэгдсэн ажгуу.

And now, my beloved brethren, for ye are my brethren, and ye ought to be beloved, and ye ought to bring forth works which are meet for repentance, seeing that your hearts have been grossly hardened against the word of God, and seeing that ye are a lost and a fallen people.

Now it came to pass that when I, Alma, had spoken these words, behold, the people were wroth with me because I said unto them that they were a hard-hearted and a stiffnecked people.

And also because I said unto them that they were a lost and a fallen people they were angry with me, and sought to lay their hands upon me, that they might cast me into prison.

But it came to pass that the Lord did not suffer them that they should take me at that time and cast me into prison.

And it came to pass that Amulek went and stood forth, and began to preach unto them also. And now the words of Amulek are not all written, nevertheless a part of his words are written in this book.



## Алма 10

- 1 Эдүгээ Аммонайхагийн нутагт байсан хүмүүст Амюлекийн номлосон тэр үгс нь эдгээр болой, хэлсэн нь:
- 2 Би бол Амюлек; би бол Аминадайн удам болох тэр Ишмэилийн хүү асан Гиддонахын хүү билээ; мөн энэ ариун сүмийн ханан дээр Бурханы хуруугаар бичигдсэн бичгийг хөрвүүлсэн мөнхүү тэр Аминадай бөлгөө.
- 3 Мөн Аминадай нь ах нарынхаа гараар Египетэд худалдагдсан Иосефын хүү асан, Манассегийн удам болох Иерусалимын нутгаас гарч ирсэн Лихайн хүү Нифайн үр удам билээ.
- 4 Мөн болгоогтун, түүнчлэн намайг мэддэг тэр бүгдийн дунд би нэр хүндээр багагүй хүн; тийм ээ, мөн болгоогтун, би олон садан төрөл мөн найзуудтай, мөн түүнчлэн би өөрийн гарын хөдөлмөрөөр их баялаг олж авсан билээ.
- 5 Гэсэн хэдий ч, энэ бүгдийн эцэст, би Их Эзэний замуд мөн түүний нууцууд мөн гайхамшигт хүчний тухайд ихийг хэзээ ч мэдэж байсангүй. Би эдгээр зүйлүүдийн тухайд ихийг хэзээ ч мэдэж байгаагүйгээ хэлсэн; гэвч болгоогтун, би алджээ, учир нь би түүний нууцууд мөн түүний гайхамшигт хүчнээс; тийм ээ, бүр энэ хүмүүсийн амьдралыг хамгаалах хамгаалалтанд ихийг үзсэн.
- 6 Гэсэн хэдий ч, би зүрх сэтгэлээ хатууруулсан, учир нь би олон удаа дуудагдсан боловч би сонсохоос татгалзсан; тиймийн тул би эдгээр зүйлүүдийн талаар мэдэж байсан боловч мэдэхийг хүссэнгүй; тиймийн тул бүр шүүгчдийн засаглалын аравдугаар оны энэхүү долдугаар сарын дөрөв дэх өдрийг хүртэл би зүрх сэтгэлийхээ ёс бусаар Бурханыг эсэргүүцсээр байсан билээ.

## Alma 10

Now these are the words which Amulek preached unto the people who were in the land of Ammonihah, saying:

I am Amulek; I am the son of Giddonah, who was the son of Ishmael, who was a descendant of Aminadi; and it was that same Aminadi who interpreted the writing which was upon the wall of the temple, which was written by the finger of God.

And Aminadi was a descendant of Nephi, who was the son of Lehi, who came out of the land of Jerusalem, who was a descendant of Manasseh, who was the son of Joseph who was sold into Egypt by the hands of his brethren.

And behold, I am also a man of no small reputation among all those who know me; yea, and behold, I have many kindreds and friends, and I have also acquired much riches by the hand of my industry.

Nevertheless, after all this, I never have known much of the ways of the Lord, and his mysteries and marvelous power. I said I never had known much of these things; but behold, I mistake, for I have seen much of his mysteries and his marvelous power; yea, even in the preservation of the lives of this people.

Nevertheless, I did harden my heart, for I was called many times and I would not hear; therefore I knew concerning these things, yet I would not know; therefore I went on rebelling against God, in the wickedness of my heart, even until the fourth day of this seventh month, which is in the tenth year of the reign of the judges.

7 Би ойрын садантайгаа уулзахаар явж байтал, болгоогтун, Их Эзэний тэнгэр элч надад үзэгдэж мөн хэлэв: Амюлек, гэртээ эргэж харь, учир нь та Их Эзэний бошиглогчийг хооллох болно; тийм ээ, Бурханаас сонгогдсон хүн болох тэр ариун хүнийг; учир нь тэр энэ хүмүүсийн нүглүүдийн учир олон өдөр мацаг барьсан, мөн тэрээр өлссөн, мөн та түүнийг гэртээ хүлээн авч мөн түүнийг хооллох болно, мөн тэр таныг мөн гэрийнхнийг тань адислах болно; мөн Их Эзэний адислал таны болон танай гэрийнхний дээр байх болно.

8 Мөнхүү улиран тохиох дор би тэнгэр элчийн дуу хоолойг дагаж, мөн гэрийнхээ зүг эргэв. Мөн би тийш явж байтал тэнгэр элчийн надад: Та гэртээ хүлээн авах болно гэж хэлсэн тэр хүнийг би олсон— мөн болгоогтун тэр нь Бурханы зүйлүүдийн талаар та нарт ярьж байсан мөнхүү тэр хүн билээ.

9 Мөн тэр бол ариун хүн гэдгийг тэнгэр элч надад хэлсэн; иймийн тул тэр бол ариун хүн гэдгийг би мэднэ, яагаад гэвэл энэ нь Бурханы тэнгэр элчээр хэлэгдсэн болой.

10 Мөн үүнчлэн, түүний гэрчилсэн зүйлүүд үнэн гэдгийг би мэднэ; учир нь болгоогтун би та нарт хэлнэ, Их Эзэн амьдын адил, үүнчлэн тэрээр өөрийн тэнгэр элчийг эдгээр зүйлийг надад мэдүүлэхээр илгээсэн юм; мөн энэ Алмаг миний гэрт амьдарч байх зуур тэрээр үүнийг хийсэн ажгуу.

11 Учир нь болгоогтун, тэрээр миний гэрийнхнийг адисалсан, тэр намайг адисалсан, мөн миний эмэгтэйчүүдийг, мөн хүүхдүүдийг минь, мөн миний эцэг хийгээд төрөл төрөгсдийг минь, тийм ээ, бүр миний бүх төрөл садангуудыг тэрээр адисалсан билээ, мөн Их Эзэний адислал түүний ярьсан үгсийн дагуу бидэн дээр байв.

12 Мөн эдүгээ, Амюлек эдгээр үгсийг ярихад хүмүүс гайхширч эхлэв, тэдний буруутгагдаж байсан тэр зүйлийг, мөн түүнчлэн ирэх тэр зүйлийг, өөрсдөд нь байсан тэрхүү бошиглолын суу билгийн дагуу гэрчилсэн нэгэн гэрчээс илүү нэгэн байсны учир болой.

As I was journeying to see a very near kindred, behold an angel of the Lord appeared unto me and said: Amulek, return to thine own house, for thou shalt feed a prophet of the Lord; yea, a holy man, who is a chosen man of God; for he has fasted many days because of the sins of this people, and he is an hungered, and thou shalt receive him into thy house and feed him, and he shall bless thee and thy house; and the blessing of the Lord shall rest upon thee and thy house.

And it came to pass that I obeyed the voice of the angel, and returned towards my house. And as I was going thither I found the man whom the angel said unto me: Thou shalt receive into thy house—and behold it was this same man who has been speaking unto you concerning the things of God.

And the angel said unto me he is a holy man; wherefore I know he is a holy man because it was said by an angel of God.

And again, I know that the things whereof he hath testified are true; for behold I say unto you, that as the Lord liveth, even so has he sent his angel to make these things manifest unto me; and this he has done while this Alma hath dwelt at my house.

For behold, he hath blessed mine house, he hath blessed me, and my women, and my children, and my father and my kinsfolk; yea, even all my kindred hath he blessed, and the blessing of the Lord hath rested upon us according to the words which he spake.

And now, when Amulek had spoken these words the people began to be astonished, seeing there was more than one witness who testified of the things whereof they were accused, and also of the things which were to come, according to the spirit of prophecy which was in them.

13 Гэсэн хэдий ч, өөрсдийн башир аргуудаар үгээр нь тэднийг буруутгаж болох тул, тэд тэдний эсрэг гэрчийг олж болохын тулд, тэд хуулийн дагуу шүүгдэж болохын тулд шүүгчдэдээ тэднийг шилжүүлж болохын тул, мөн өөрсдийн илрүүлэх эсвээс гэрчлэх тэр гэмт хэргийн дагуу, тэд алагдаж эсвээс шоронд хаягдаж болохын тулд тэднийг шалгаахыг бодсон зарим нь тэдний дунд байв.

14 Эдүгээ энэ нь тэднийг устгахыг эрэлхийлсэн, хуульчид болох тэр, шүүгчдийн өмнө хүмүүсийн гэмт хэргүүдийг шүүх хурал дээр эсвээс шүүх хурлын үеэр хуулийг хэрэгжүүлэхээр хүмүүсээр томилогдсон эсвээс хөлслөгдсөн, тэдгээр хүмүүс байсан бөлгөө.

15 Эдүгээ эдгээр хуульчид хүмүүсийн бүх башир арга мөн чадваруудад суралцсан байв; мөн энэ нь мэргэжилдээ чадамгай байж болох тэрхүү боломжийг олгохын тулд тэдэнд байсан болой.

16 Мөнхүү улиран тохиох дор тэд, ингэснээрээ тэд түүний өөрийнх нь үгсийг зөрөлдүүлэх буюу түүний ярих үгсийг няцааж болохын тулд Амюлекийг шалгааж эхлэв.

17 Эдүгээ тэд Амюлек өөрсдийнх нь төлөвлөгөөний тухайд мэдэж чадна гэдгийг тэд мэдсэнгүй. Гэвч улиран тохиох дор тэд түүнийг шалгааж эхлэхэд, тэрээр тэдний бодлыг ойлгож, мөн тэр тэдэнд хэлэв: Ай ёс бус хийгээд тэрс үеийнхэн та нар, хуульчид мөн хоёр нүүртнүүд та нар, учир нь та нар чөтгөрийн суурийг тавьж байна; учир нь та нар Бурханы ариун хүмүүс болох тэднийг барих хавх хийгээд занга тавьж байна.

18 Та нар зөв шударгын замуудыг гажуудуулах мөн Бурханы хилэнг толгой дээрээ доош авчрах, бүр энэ хүмүүсийг бүрмөсөн устгалд хүргэх төлөвлөгөөнүүдийг зэхэж байна.

19 Тийм ээ, бидний сүүлчийн хаан асан Мозая зөвөөр хэлсэн, тэрээр хаант улсыг өгөх гэж байх үедээ үүнийг шилжүүлэн өгөх хэн ч үгүй байснаас, энэ хүмүүс өөрсдийн саналаар засаглагдахаар болгоод— тийм ээ, хэрэв энэ хүмүүсийн санал алдсыг сонгох тэр цаг ирэх аваас, тодруулбал, хэрэв энэ хүмүүс зөрчилд унах тэр цаг ирвэл, тэд устгалд бэлэн болон боловсорч гүйцсэн байна хэмээн тэрбээр зөвийг хэлсэн авай.

Nevertheless, there were some among them who thought to question them, that by their cunning devices they might catch them in their words, that they might find witness against them, that they might deliver them to their judges that they might be judged according to the law, and that they might be slain or cast into prison, according to the crime which they could make appear or witness against them.

Now it was those men who sought to destroy them, who were lawyers, who were hired or appointed by the people to administer the law at their times of trials, or at the trials of the crimes of the people before the judges.

Now these lawyers were learned in all the arts and cunning of the people; and this was to enable them that they might be skilful in their profession.

And it came to pass that they began to question Amulek, that thereby they might make him cross his words, or contradict the words which he should speak.

Now they knew not that Amulek could know of their designs. But it came to pass as they began to question him, he perceived their thoughts, and he said unto them: O ye wicked and perverse generation, ye lawyers and hypocrites, for ye are laying the foundations of the devil; for ye are laying traps and snares to catch the holy ones of God.

Ye are laying plans to pervert the ways of the righteous, and to bring down the wrath of God upon your heads, even to the utter destruction of this people.

Yea, well did Mosiah say, who was our last king, when he was about to deliver up the kingdom, having no one to confer it upon, causing that this people should be governed by their own voices—yea, well did he say that if the time should come that the voice of this people should choose iniquity, that is, if the time should come that this people should fall into transgression, they would be ripe for destruction.

- 20 Мөн эдүгээ Их Эзэн та нарын алдсуудыг зөвөөр шүүдгийг би та нарт хэлнэ; тэрээр энэ хүмүүст тэнгэр элчийнхээ дуу хоолойгоор: Наманчлагтун та нар, наманчил, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна хэмээн зөвөөр хашгирсан болой.
- 21 Тийм ээ, тэнгэр элчүүдийнхээ дуу хоолойгоор тэрээр зөвөөр хашгирдаг; би мутартаа тэгш эрх мөн шударга ёсыг барин өөрийн хүмүүсийн дунд доошлон ирэх болно хэмээсэн ажгуу.
- 22 Тийм ээ, мөн хэрэв энэ нутагт одоо байгаа зөв шударгыг үйлдэгчдийн залбирлууд үгүй сэн бол, та нар бүр одоо ч бүрмөсөн сүйрэх устгалаар зочлогдох байсныг би та нарт хэлнэ; гэвч энэ нь Ноагийн өдрүүдэд хүмүүст ирсэн шиг үерээр байх нь үгүй, харин энэ нь өлсгөлөнгөөр мөн тахлаар мөн илдээр байх болно.
- 23 Гэвч та нар хэлтрүүлэгдэхийн учир нь зөв шударгыг үйлдэгчдийг залбирлуудаар буюу; эдүгээ тиймийн тул, хэрэв та нар өөрсдийнхөө дундаас зөв шударгыг үйлдэгчдийг зайлуулах аваас Их Эзэн мутраа хумхиад суухгүй; харин тэрээр догшин хилэндээ тэр та нарын эсрэг гарч ирэх болно; тэгээд та нар өлсгөлөнгөөр, мөн тахлаар, мөн илдээр цохигдох болно; мөн та нар наманчлахгүй аваас тэр цаг удахгүй, дөхөж байна.
- 24 Мөн эдүгээ улиран тохиох дор хүмүүс Амюлект улам уурлаж, мөн тэд хашгиралдаж, өгүүлсэн нь: Энэ хүн бидний шударга хуулиудыг мөн бидний сонгосон цэцэн шүүгчдийг эсэргүүцэн доромжилж байна.
- 25 Гэвч Амюлек гараа урагш сунган, мөн тэдэнд илүү хүчтэйгээр хашгирч, хэлсэн нь: Ай ёс бус хийгээд тэрс үеийнхэн та нар, Сатан та нарын зүрх сэтгэлд яагаад ийм их байрыг эзлэв? Яригдсан үгсийг үнэний нь дагуу та нарт ойлгуулахгүй байхын тулд, тэрээр та нарын дээр нүдийг чинь харалган болгохоор хүчтэй байж болохын тулд та нар өөрсдөө яагаад түүнд бууж өгөв
- 26 Учир нь болгоогтун, би та нарын хуулийн эсрэг гэрчилсэн гэж үү? Та нар эс ойлгоно; намайг хуулийн чинь эсрэг ярьсан гэж та нар хэлнэ; гэвч би тэгсэнгүй; харин би хуулийн чинь төлөө, та нарын буруушаалтын тулд ярьсан билээ.

And now I say unto you that well doth the Lord judge of your iniquities; well doth he cry unto this people, by the voice of his angels: Repent ye, repent, for the kingdom of heaven is at hand.

Yea, well doth he cry, by the voice of his angels that: I will come down among my people, with equity and justice in my hands.

Yea, and I say unto you that if it were not for the prayers of the righteous, who are now in the land, that ye would even now be visited with utter destruction; yet it would not be by flood, as were the people in the days of Noah, but it would be by famine, and by pestilence, and the sword.

But it is by the prayers of the righteous that ye are spared; now therefore, if ye will cast out the righteous from among you then will not the Lord stay his hand; but in his fierce anger he will come out against you; then ye shall be smitten by famine, and by pestilence, and by the sword; and the time is soon at hand except ye repent.

And now it came to pass that the people were more angry with Amulek, and they cried out, saying: This man doth revile against our laws which are just, and our wise lawyers whom we have selected.

But Amulek stretched forth his hand, and cried the mightier unto them, saying: O ye wicked and perverse generation, why hath Satan got such great hold upon your hearts? Why will ye yield yourselves unto him that he may have power over you, to blind your eyes, that ye will not understand the words which are spoken, according to their truth?

For behold, have I testified against your law? Ye do not understand; ye say that I have spoken against your law; but I have not, but I have spoken in favor of your law, to your condemnation.

27 Мөн эдүгээ болгоогтун, энэ хүмүүсийн устгалын суурь нь танай хуульчид мөн шүүгчдийн зөв шударга бус байдлаар тавигдаж эхэлж байна гэдгийг би та нарт хэлнэ.

28 Мөн Эдүгээ улиран тохиох дор Амюлек эдгээр үгсийг ярихад хүмүүс түүний эсрэг хашгиралдаж, өгүүлсэн нь: эдүгээ бид энэ хүн чөтгөрийн хүүхэд гэдгийг мэдлээ, учир нь тэр бидэнд худал хэллээ; учир нь тэр бидний хуулийн эсрэг ярилаа. Мөн эдүгээ тэр үүний эсрэг яриагүй хэмээн хэлж байна.

29 Мөн үүнчлэн, тэрээр бидний хуульчдын мөн бидний шүүгчдийн эсрэг доромжлов.

30 Мөн улиран тохиох дор эдгээр зүйлийг түүний эсрэг тэд санахын тулд хуульчид үүнийг зүрх сэтгэлдээ хадгалсан ажгуу.

31 Мөн тэдний дунд Зиезром гэж нэрлэгдсэн нэгэн байв. Эдүгээ тэр нь Амюлек болон Алмаг буруутгах тэдний дунд хамгийн нөлөө бүхий нэгэн байв; тэрээр хүмүүсийн дунд их хэргийг хийдэг байсан учир тэдний дундаас хамгийн мэргэжсэн нэгэн байв.

32 Эдүгээ эдгээр хуульчдын эрмэлзэл нь хөрөнгөжих явдал байв; мөн тэд ажлынхаа дагуу хөрөнгөжсөн ажээ.

And now behold, I say unto you, that the foundation of the destruction of this people is beginning to be laid by the unrighteousness of your lawyers and your judges.

And now it came to pass that when Amulek had spoken these words the people cried out against him, saying: Now we know that this man is a child of the devil, for he hath lied unto us; for he hath spoken against our law. And now he says that he has not spoken against it.

And again, he has reviled against our lawyers, and our judges.

And it came to pass that the lawyers put it into their hearts that they should remember these things against him.

And there was one among them whose name was Zeetzrom. Now he was the foremost to accuse Amulek and Alma, he being one of the most expert among them, having much business to do among the people.

Now the object of these lawyers was to get gain; and they got gain according to their employ.

## Алма 11

- 1 Эдүгээ Мозаягийн хуулинд, хуулийн шүүгч байсан хүн бүр өөрөөр хэлбэл шүүгчид байхаар томилогдсон тэд өөрсдийнх нь өмнө шүүгдэхээр авчрагдсан тэднийг шүүхээр хөдөлмөрлөсөн тэр цагийнхаа дагуу хөлс авах ёстой хэмээсэн байлаа.
- 2 Эдүгээ хэрэв хүн өөр нэгэнд өртэй, мөн тэр тавьсан өрөө төлөхгүй бол, тэрээр шүүгчид мэдүүлэгддэг байв; мөн шүүгч эрх мэдлээ ашиглан үйлдэж, мөн уг хүнийг өөрийн өмнө авчруулахаар албан тушаалтныг илгээдэг байв; мөн тэрээр уг хүнийг хуулийн, мөн түүний эсрэг өгсөн мэдүүлгийн дагуу шүүж, мөн тийн уг хүн тавьсан өрөө төлөхөөр албадагдаж, эсвээс хөрөнгөнөөсөө хураалгаж, эсвээс хулгайч мөн дээрэмчний адил хүмүүсийн дундаас зайлуулагддаг байсан ажгуу.
- 3 Мөн шүүгч цагийнхаа дагуу өөрийн хөлсийг авдаг—өдөрт нэг алтан синайн, эсвэл алтан синайнтай тэнцэх, мөнгөн сенамыг буюу; мөн энэ нь өгөгдсөн хуулийн дагуу бөлгөө.
- 4 Эдүгээ эдгээр нь үнэ цэнийн нь дагуу алтны болон мөнгөнийх нь ялгаатай хэсгүүдийн нэрс буюу. Мөн уг нэрс нифайчуудаар өгөгджээ, учир нь тэд Иерусалимд байсан иудейчүүдийн маягаар тооцоолдоггүй байсан аж; бас иудейчүүдийн маягаар хэмждэг ч үгүй байв; харин шүүгчдийн засаглалыг хүртэл үе болгонд, тэд хүмүүсийн бодол мөн нөхцөлийн дагуу, өөрсдийн өртөг болоод өөрсдийн хэмжүүрийг өөрчилж байжээ, мөн эдгээр нь хаан Мозаягаар тогтоогдсон буюу.
- 5 Эдүгээ тооцоолох нь ийм буюу—алтан синайн, алтан сион, алтан шаам, алтан лимна.
- 6 Мөнгөн синам, мөнгөн амнор, мөнгөн эзром, мөн мөнгөн онтай.
- 7 Нэг мөнгөн синам нь нэг алтан синайнтай тэнцэж, мөн аль аль нь нэг тогоо арвайг хэмжихийн тулд, мөн түүнчлэн бүх төрлийн нэг тогоо будаатай тэнцэж байв.
- 8 Эдүгээ нэг алтан сион нь хоёр синайны дайтай байв.
- 9 Мөн нэг алтан шаам нь хоёр сионы дайтай байв.

## Alma 11

Now it was in the law of Mosiah that every man who was a judge of the law, or those who were appointed to be judges, should receive wages according to the time which they labored to judge those who were brought before them to be judged.

Now if a man owed another, and he would not pay that which he did owe, he was complained of to the judge; and the judge executed authority, and sent forth officers that the man should be brought before him; and he judged the man according to the law and the evidences which were brought against him, and thus the man was compelled to pay that which he owed, or be stripped, or be cast out from among the people as a thief and a robber.

And the judge received for his wages according to his time—a senine of gold for a day, or a senum of silver, which is equal to a senine of gold; and this is according to the law which was given.

Now these are the names of the different pieces of their gold, and of their silver, according to their value. And the names are given by the Nephites, for they did not reckon after the manner of the Jews who were at Jerusalem; neither did they measure after the manner of the Jews; but they altered their reckoning and their measure, according to the minds and the circumstances of the people, in every generation, until the reign of the judges, they having been established by king Mosiah.

Now the reckoning is thus—a senine of gold, a seon of gold, a shum of gold, and a limnah of gold.

A senum of silver, an amnor of silver, an ezrom of silver, and an onti of silver.

A senum of silver was equal to a senine of gold, and either for a measure of barley, and also for a measure of every kind of grain.

Now the amount of a seon of gold was twice the value of a senine.

And a shum of gold was twice the value of a seon.

10 Мөн нэг алтан лимна нь тэднийг бүгдийг нэгтгэсний дайтай байв.

11 Мөн нэг мөнгөн амнор нь хоёр синамтай дүйцэхүйц их байв.

12 Мөн нэг мөнгөн эзром нь дөрвөн синамтай дүйцэхүйц их байв.

13 Мөн нэг онтай нь тэднийг бүгдийг нэгтгэсэнтэй дүйцэхүйц их байв.

14 Эдүгээ энэ нь тэдний өртгийг тооцоолох бага нэгжүүд—

15 Нэг шиблон нь хагас синам; тиймийн тул, нэг шиблон нь тогоо арвайн хагас нь.

16 Мөн нэг шиблам нь хагас шиблон болно.

17 Мөн нэг лий нь хагас шиблам болно.

18 Эдүгээ энэ нь тэдний тооцооны дагуух нэгж нь болой.

19 Эдүгээ нэг алтан антион нь гурван шиблонтой тэнцэнэ.

20 Эдүгээ энэ нь хөрөнгө хураах цорын ганц зорилгын төлөө байв, яагаад гэвэл тэд ажилласныхаа дагуу хөлсөө авдаг, тиймийн тул, тэд өөрсдөө илүү их ажилтай байж, тэдний өмнө авчрагдсан шүүх үйл ажиллагааны дагуу мөнгө олж болохын тулд тэд хүмүүсийг үймээнд, мөн бүх төрлийн дураараа авирлах явдалд мөн ёс бусад өдөөн хатгадаг байлаа; тиймийн тул тэд хүмүүсийг Алма Амюлек нарын эсрэг өдөөн хатгав.

21 Мөн энэ Зиезром Амюлекийг шалгааж эхлэв, өгүүлсэн нь: Та нар өөрсдөөс чинь миний асуух хэдэн асуултанд хариулаач? Эдүгээ Зиезром зөв сайн болох түүнийг устгаж болохын тулд чөтгөрийн аргуудад мэргэжсэн хүн байв; тиймийн тул, тэрээр Амюлект: Та нар өөрсдөд чинь миний тавих асуултуудад хариулна уу? хэмээв.

22 Мөн Амюлек түүнд хэлэв: Тийм ээ, хэрэв энэ нь надад орших Их Эзэний Сүнсний дагуу байх аваас; учир нь би Их Эзэний Сүнсний эсрэг юу ч хэлэхгүй. Мөн Зиезром түүнд хэлсэн нь: Болгоогтун, энд зургаан мөнгөн онтай байна, мөн хэрэв та Эрхэм Агуу Нэгэний оршин буйг үгүйсгэх аваас би энэ бүгдийг танд өгөх болно.

And a limnah of gold was the value of them all.

And an amnor of silver was as great as two senums.

And an ezrom of silver was as great as four senums.

And an onti was as great as them all.

Now this is the value of the lesser numbers of their reckoning—

A shiblon is half of a senum; therefore, a shiblon for half a measure of barley.

And a shiblum is a half of a shiblon.

And a Leah is the half of a shiblum.

Now this is their number, according to their reckoning.

Now an antion of gold is equal to three shiblons.

Now, it was for the sole purpose to get gain, because they received their wages according to their employ, therefore, they did stir up the people to riotings, and all manner of disturbances and wickedness, that they might have more employ, that they might get money according to the suits which were brought before them; therefore they did stir up the people against Alma and Amulek.

And this Zeezrom began to question Amulek, saying: Will ye answer me a few questions which I shall ask you? Now Zeezrom was a man who was expert in the devices of the devil, that he might destroy that which was good; therefore, he said unto Amulek: Will ye answer the questions which I shall put unto you?

And Amulek said unto him: Yea, if it be according to the Spirit of the Lord, which is in me; for I shall say nothing which is contrary to the Spirit of the Lord. And Zeezrom said unto him: Behold, here are six onties of silver, and all these will I give thee if thou wilt deny the existence of a Supreme Being.

23 Эдүгээ Амюлек хэлэв: Ай тамын хүүхэд чи, юуны учир намайг уруу татнав? Зөв шударгыг үйлдэгсэд ямар ч иймэрхүү уруу таталганд бууж өгдөггүйг чи мэдэх үү

24 Бурхан үгүй гэдэгт чи итгэнэ үү? Би чамд хэлнэ, Үгүй, Бурхан бийг чи мэднэ, харин чи ашиг орлогыг түүнээс илүүгээр хайрладаг ажээ.

25 Хэдийгээр зүрх сэтгэлдээ үүнийг надад өгөлгүй өөртөө үлдээхээр байлаач—энэ их үнэ болох зургаан онтайг болгоогтун, би танд өгөх болно—хэмээн та надад хэллээ. Мөн чи намайг устгах шалтаг олж болохын тулд би үнэн бөгөөд амьд Бурханыг үгүйсгэх нь чиний цорын ганц хүсэл байсан. Мөн эдүгээ болгоогтун, энэхүү их хилэнцийн төлөө чи шангаа хүртэх болно.

26 Мөн Зиезром түүнд хэлэв: Үнэн бөгөөд амьд Бурхан байдаг гэж та хэлэв үү

27 Мөн Амюлек хэлэв: Тийм ээ, үнэн бөгөөд амьд Бурхан байдаг.

28 Эдүгээ Зиезром хэлсэн нь: Нэгээс илүү Бурхан байдаг уу

29 Мөн тэр, Үгүй гэж хариулав.

30 Эдүгээ Зиезром түүнд тэрчлэн хэлсэн нь: Та эдгээр зүйлийг яаж мэдэв

31 Мөн тэр хэлсэн нь: Нэгэн тэнгэр элч надад эдгээрийг мэдүүлсэн билээ.

32 Мөн Зиезром үүнчлэн хэлэв: Ирэх тэр нь хэн билээ? Тэр нь Бурханы Хүү мөн үү

33 Мөн тэрээр түүнд, Тийм хэмээн хэлэв.

34 Мөн Зиезром түүнд үүнчлэн хэлсэн нь: Тэрээр нүгэлдээ буй өөрийн хүмүүсийг аврах уу? Мөн Амюлек хариулж мөн түүнд хэлэв: Би танд хэлнэ, тэр тэгэхгүй, учир нь өөрийн үгийг үгүйсгэх нь түүнд боломжгүй бөлгөө.

35 Эдүгээ Зиезром хүмүүст хэлсэн нь: Та нар эдгээр зүйлийг санахаа мэд; учир нь тэрээр цорын ганц Бурхан буй гэж хэлэв; гэсэн ч тэр Бурханы Хүү ирэх болно, харин Бурханд зарлиглах эрх мэдэл түүнд буй мэтээр тэр өөрийн хүмүүсийг аврахгүй хэмээв—

Now Amulek said: O thou child of hell, why tempt ye me? Knowest thou that the righteous yieldeth to no such temptations?

Believest thou that there is no God? I say unto you, Nay, thou knowest that there is a God, but thou lovest that lucre more than him.

And now thou hast lied before God unto me. Thou saidst unto me—Behold these six onties, which are of great worth, I will give unto thee—when thou hadst it in thy heart to retain them from me; and it was only thy desire that I should deny the true and living God, that thou mightest have cause to destroy me. And now behold, for this great evil thou shalt have thy reward.

And Zeezrom said unto him: Thou sayest there is a true and living God?

And Amulek said: Yea, there is a true and living God.

Now Zeezrom said: Is there more than one God?

And he answered, No.

Now Zeezrom said unto him again: How knowest thou these things?

And he said: An angel hath made them known unto me.

And Zeezrom said again: Who is he that shall come? Is it the Son of God?

And he said unto him, Yea.

And Zeezrom said again: Shall he save his people in their sins? And Amulek answered and said unto him: I say unto you he shall not, for it is impossible for him to deny his word.

Now Zeezrom said unto the people: See that ye remember these things; for he said there is but one God; yet he saith that the Son of God shall come, but he shall not save his people—as though he had authority to command God.



36 Эдүгээ Амюлек тэрчлэн түүнд хэлэв: Болгоогтун та худал хэлэв, учир нь та намайг Бурханд зарлиглах эрх мэдэлтэй мэтээр ярьсан хэмээн хэлж байна, би нүгэлдээ буй өөрийн хүмүүсийг тэрээр аврахгүйг би хэлсний учир болой.

37 Мөн тэрээр нүгэлдээ буй тэднийг аварч чадахгүй хэмээн би та нарт дахин хэлнэ; учир нь би түүний үгийг үгүйсгэж чадахгүй мөн тэрээр цэвэр бус нэг ч зүйл тэнгэрийн хаант улсыг өвлөж чадахгүй гэж хэлсэн; тиймийн тул, та нар тэнгэрийн хаант улсыг өвлөхгүйгээр та нар хэрхэн аврагдаж чадах билээ? Тиймийн тул, та нар нүгэлдээ байхдаа аврагдаж чадахгүй.

38 Эдүгээ Зиезром түүнд дахин хэлэв: Бурханы Хүү нь чухам тэрхүү Мөнхийн Эцэг юм уу

39 Мөн Амюлек түүнд хэлэв: Тийм ээ, тэр бол тэнгэр мөн газрын, мөн тэдэнд багтах бүх зүйлийн чухамхүү тэр Мөнхийн Эцэг буюу; тэр бол эхлэл ба төгсгөл, эхнийх бөгөөд эцсийнх болой;

40 Мөн тэрбээр өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр дэлхийд ирэх болно; мөн тэрээр өөрийнх нь нэрэнд итгэх тэдний зөрчлүүдийг өөр дээрээ авах болно; мөн эдгээр нь мөнх амьдралыг авах тэд болой, мөн өөр хэнд ч аврал ирэхгүй.

41 Тиймийн тул ёс бусыг үйлдэгчдийн үхлийн хүлээ алдуурахаас бусдаар, гэтэлгэл хийгдээгүй мэтээр үлдэнэ; учир нь болгоогтун, бүгд нас барагсдын дундаас босч мөн Бурханы өмнө зогсоно, мөн үйлүүдийнхээ дагуу шүүгдэх тэр өдөр ирэх болно.

42 Эдүгээ зуурдын үхэл гэж нэрлэгдсэн үхэл байдаг; мөн Христийн үхэл нь энэ зуурдын үхлийн хүлээсийг тайлнаар, бүгд зуурдын үхлээс босгогдох болно.

43 Сүнс мөн бие төгс хэлбэрээрээ дахин нэгдэх болно; бүр бид одоо энэ цагт байгаа шигээ, үе болон мөч аль аль нь зохих байдалдаа сэргээгдэх болно; мөн бид Бурханы өмнө одоогийнхоо мэдэж буйн адил мэдлэгтэйгээр, мөн өөрсдийн бүх гэмийн тодорхой дурдатгалтайгаар зогсохоор аваачигдах болно.

Now Amulek saith again unto him: Behold thou hast lied, for thou sayest that I spake as though I had authority to command God because I said he shall not save his people in their sins.

And I say unto you again that he cannot save them in their sins; for I cannot deny his word, and he hath said that no unclean thing can inherit the kingdom of heaven; therefore, how can ye be saved, except ye inherit the kingdom of heaven? Therefore, ye cannot be saved in your sins.

Now Zeezrom saith again unto him: Is the Son of God the very Eternal Father?

And Amulek said unto him: Yea, he is the very Eternal Father of heaven and of earth, and all things which in them are; he is the beginning and the end, the first and the last;

And he shall come into the world to redeem his people; and he shall take upon him the transgressions of those who believe on his name; and these are they that shall have eternal life, and salvation cometh to none else.

Therefore the wicked remain as though there had been no redemption made, except it be the loosing of the bands of death; for behold, the day cometh that all shall rise from the dead and stand before God, and be judged according to their works.

Now, there is a death which is called a temporal death; and the death of Christ shall loose the bands of this temporal death, that all shall be raised from this temporal death.

The spirit and the body shall be reunited again in its perfect form; both limb and joint shall be restored to its proper frame, even as we now are at this time; and we shall be brought to stand before God, knowing even as we know now, and have a bright recollection of all our guilt.

44 Эдүгээ энэ сэргээлт нь бүгдэд, настай мөн залуу аль алинд нь, боол мөн чөлөөт аль алинд нь, эрэгтэй эмэгтэй аль алинд нь, ёс бусыг үйлдэгчид хийгээд зөв шударгыг үйлдэгчдэд аль алинд нь ирэх болно; мөн бүр тэдний толгойн үсний нэг ширхэг нь ч гээгдэхгүй болой; харин бүх зүйл төгс хэлбэрээрээ одоогийнхоо адил өөрөөр хэлбэл биедээ буй мэтээр, сэргээгдэх болно, мөн нэгэн Мөнхийн Бурхан болох Хүү Христ, мөн Эцэг Бурхан, мөн Ариун Сүнсний тавцангийн өмнө өөрсдийн сайн ч бай, мөн хилэнцэт ч бай, тэрхүү үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр авчрагдаж мөн яллагдах болно.

45 Эдүгээ, болгоогтун, би танд зуурдын биеийн үхлийн талаар мөн түүнчлэн зуурдын биеийн амилуулалтын талаар ярьсан билээ. Энэ зуурдын бие үхэшгүй биед, тодруулбал үхлээс, бүр амьдралын эхний үхлээс босгогдоно, тэд дахин нэгээхэн ч үхэж чадахгүй болно хэмээн би та нарт хэлнэ; тэдний сүнснүүд биестэйгээ хэзээ ч салгагдахгүйгээр нэгдэнэ; тэд дахин ялзралыг үзэж чадахгүй болж, тийн бүхэл бүтнээрээ сүнсний хийгээд үхэшгүй байдалтай болно.

46 Эдүгээ, Амюлек эдгээр үгсийг дуусгахад хүмүүс дахин гайхан цочирдож эхлэв, мөн түүнчлэн Зиезром салгалж эхлэв. Мөн тийн Амюлекийн үгс төгсөж, өөрөөр хэлбэл миний бичиглэсэн бүхэн нь энэ болов.

Now, this restoration shall come to all, both old and young, both bond and free, both male and female, both the wicked and the righteous; and even there shall not so much as a hair of their heads be lost; but every thing shall be restored to its perfect frame, as it is now, or in the body, and shall be brought and be arraigned before the bar of Christ the Son, and God the Father, and the Holy Spirit, which is one Eternal God, to be judged according to their works, whether they be good or whether they be evil.

Now, behold, I have spoken unto you concerning the death of the mortal body, and also concerning the resurrection of the mortal body. I say unto you that this mortal body is raised to an immortal body, that is from death, even from the first death unto life, that they can die no more; their spirits uniting with their bodies, never to be divided; thus the whole becoming spiritual and immortal, that they can no more see corruption.

Now, when Amulek had finished these words the people began again to be astonished, and also Zeezrom began to tremble. And thus ended the words of Amulek, or this is all that I have written.

## Алма 12

- 1 Эдүгээ Амюлекийн үгс Зиезромыг чимээгүй болгосныг Алма хараад, Амюлек түүнийг худал хэлж мөн өөрийг нь сүйрүүлэхээр мэхэлж байгааг илчилснийг нь тэр мэдсэний учир, мөн өөрийн зөрчлийг ухамсарласнаас түүний салгалж эхлэхийг Алма хараад, тэрээр амаа нээж мөн түүнд ярьж, мөн Амюлекийн үгсийг батлан, мөн юмсыг илүүгээр тайлбарлан, өөрөөр хэлбэл Амюлекийн хийснээс илүүгээр судруудыг дэлгэн тайлбарлаж эхлэв.
- 2 Эдүгээ Зиезромд ярьсан Алмагийн үгс эргэн тойронд нь байсан хүмүүст дуулдав; учир нь түмэн олон агуу олон тоотой байв, мөн тэрээр ийм маягаар ярив:
- 3 Эдүгээ Зиезром, таны худал хэлж мөн залилсан тань баригдсаныг харлаа, учир нь та зөвхөн хүмүүнд худал хэлсэн бус, харин та Бурханд худал хэллээ; учир нь болгоогтун, тэр таны бүх бодлуудыг мэддэг, мөн таны бодлууд түүний Сүнсээр бидэнд мэдүүлэгдсэнийг та харж байна;
- 4 Мөн биднийг гадуурхан мөн биднийг зайлуулахаар, энэ хүмүүсийг бидний эсрэг болгож болохын тулд тэднийг та хуурч мөн худал хэлэхийн тулд таны төлөвлөгөө чөтгөрийн зальт аргын дагуу машинд зальт төлөвлөгөө байсныг бид мэдсэнийг та харж байна—
- 5 Эдүгээ энэ нь таны дайсны төлөвлөгөө байсан, мөн тэрээр өөрийн хүчийг танаар дамжуулан үзүүлсэн бөлгөө. Эдүгээ би танд хэлснийг бүгдэд хэлж буйг та нар санаасай хэмээнэ.
- 6 Мөн болгоогтун, тэр та нарыг боолчлох хүчний хээ дагуу үүрдийн устгалд доош гинжилж болохын тулд, тэр та нарыг гинжээрээ ороож болохын тулд, тэр та нарыг эрхшээлдээ авчрахын тулд, энэ бол дайсны, тэрбээр энэ хүмүүсийг барихаар тавьсан урхи байсныг би та бүгдэд хэлнэ.

## Alma 12

Now Alma, seeing that the words of Amulek had silenced Zeezrom, for he beheld that Amulek had caught him in his lying and deceiving to destroy him, and seeing that he began to tremble under a consciousness of his guilt, he opened his mouth and began to speak unto him, and to establish the words of Amulek, and to explain things beyond, or to unfold the scriptures beyond that which Amulek had done.

Now the words that Alma spake unto Zeezrom were heard by the people round about; for the multitude was great, and he spake on this wise:

Now Zeezrom, seeing that thou hast been taken in thy lying and craftiness, for thou hast not lied unto men only but thou hast lied unto God; for behold, he knows all thy thoughts, and thou seest that thy thoughts are made known unto us by his Spirit;

And thou seest that we know that thy plan was a very subtle plan, as to the subtlety of the devil, for to lie and to deceive this people that thou mightest set them against us, to revile us and to cast us out—

Now this was a plan of thine adversary, and he hath exercised his power in thee. Now I would that ye should remember that what I say unto thee I say unto all.

And behold I say unto you all that this was a snare of the adversary, which he has laid to catch this people, that he might bring you into subjection unto him, that he might encircle you about with his chains, that he might chain you down to everlasting destruction, according to the power of his captivity.

7 Эдүгээ Алма эдгээр үгсийг ярихад Зиезром үлэмж ихээр салгалж эхлэв, учир нь тэрээр Бурханы хүчинд улам улам бүр үнэмшүүлэгдэж байв; мөн түүнчлэн Алма Амюлек нарт өөрийнх нь тухай мэдлэг буй гэдэгт тэрээр үнэмшүүлэгдэв, учир нь түүний зүрхний бодлууд болоод санаануудыг тэд мэдсэнд тэрээр үнэмшүүлэгдэв; учир нь бошиглолын суу билгийн дагуу тэд эдгээр зүйлийг мэдэж болохын тулд тэдэнд хүч өгөгдсөн байв.

8 Мөн Зиезром Бурханы хаант улсын талаар илүү мэдэж болохын тулд тэрээр тэднээс шаргуугаар лавлаж эхлэв. Мөн тэр Алмад хэлэв: нас барагсдын амилуулалтын талаар Амюлекийн ярьсан тэр, шударга, шударга бус аль аль нь бүгд нас барагсдын дундаас босох болно, мөн өөрсдийн хийсэн үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр Бурханы өмнө зогсохоор авчрагдах гэдэг нь юу гэсэн утгатай билээ

9 Мөн эдүгээ Алма эдгээр зүйлийг түүнд тайлбарлаж эхлэв, өгүүлсэн нь: Бурханы нууцуудыг мэдэх нь олонд өгөгдсөн юм; гэсэн хэдий ч тэдний түүнд хандуулах тэрхүү анхаарал мөн шаргуу байдлын хэрээр хүмүүний үрсэд соёрхдог үгсийн зөвхөн тэр хэсгийн дагуу л бус аваас хуваалцаж үл болно гэсэн чанд хатуу зарлигийг тэд хүлээсэн байдаг.

10 Мөн тиймийн тул, зүрх сэтгэлээ хатууруулах тэр нь, мөнхүү тэр нь үгийн багахан хувийг хүлээж авдаг; мөн зүрх сэтгэлээ хатууруулахгүй, түүнд тэдгэрийг бүрэн дүүрэн мэдэх хүртэл нь Бурханы нууцуудыг түүнд мэдүүлэх хүртэл үгийн илүү их хэсэг өгөгддөг болой.

11 Мөн зүрх сэтгэлээ хатууруулах, тэдэнд нууцуудын талаар юу ч мэдэхгүй болох хүртэл нь үгийн илүү бага хэсэг өгөгддөг; мөн тэгээд тэд чөтгөрийн боолчлолд автагдаж, мөн түүний тааллаар доош устгал уруу удирдагддаг. Эдүгээ тамын гинж гэдэг нь ийм учиртай ажгуу.

12 Мөн үхэл хийгээд энэхүү зуурдын байдлаас үхэшгүй байдалд босгогдохоор, мөн өөрсдийн үйлүүдийн дагуу шүүгдэхээр, Бурханы тавцангийн өмнө авчрагдах талаар Амюлек тодорхой ярьсан ажгуу.

Now when Alma had spoken these words, Zeezrom began to tremble more exceedingly, for he was convinced more and more of the power of God; and he was also convinced that Alma and Amulek had a knowledge of him, for he was convinced that they knew the thoughts and intents of his heart; for power was given unto them that they might know of these things according to the spirit of prophecy.

And Zeezrom began to inquire of them diligently, that he might know more concerning the kingdom of God. And he said unto Alma: What does this mean which Amulek hath spoken concerning the resurrection of the dead, that all shall rise from the dead, both the just and the unjust, and are brought to stand before God to be judged according to their works?

And now Alma began to expound these things unto him, saying: It is given unto many to know the mysteries of God; nevertheless they are laid under a strict command that they shall not impart only according to the portion of his word which he doth grant unto the children of men, according to the heed and diligence which they give unto him.

And therefore, he that will harden his heart, the same receiveth the lesser portion of the word; and he that will not harden his heart, to him is given the greater portion of the word, until it is given unto him to know the mysteries of God until he know them in full.

And they that will harden their hearts, to them is given the lesser portion of the word until they know nothing concerning his mysteries; and then they are taken captive by the devil, and led by his will down to destruction. Now this is what is meant by the chains of hell.

And Amulek hath spoken plainly concerning death, and being raised from this mortality to a state of immortality, and being brought before the bar of God, to be judged according to our works.

13 Тэгээд хэрэв бидний зүрх сэтгэл хатуурсан бол, тийм ээ, хэрэв бид үгний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулсан бол, үүний хэрээр энэ нь бидний дотор олоогүй аваас, тэгвэл бидний нөхцөл аймшигтай байх болно, учир нь бид буруутгагдах болно.

14 Учир нь бидний үгс биднийг буруутгах болно, тийм ээ, бүх үйлс маань биднийг буруутгах болно; бид толбогүйгээр эс тогтоогдох болно; мөн түүнчлэн бодлууд маань ч биднийг буруутгах болно; мөн энэ аймшигт нөхцөлд бид өөрсдийн Бурхан өөд маань харж үл зүрхлэх болно; мөн түүний оршихуйгаас биднийг нуухын тулд, өөрсөд дээрээ нуран унахыг хад уулсад бид тушааж чаддаг сан бол сэтгэл маань ихэд баяртай байх сан биз ээ.

15 Гэвч ийм байх аргагүй юм; бид урагшлан мөн түүний өмнө, түүний алдар суугийн дор, мөн түүний хүчний дор, мөн түүний чадал, сүр жавхлангийн хийгээд эзэгнэлийн дор зогсон, түүний бүхий л шүүлтүүд шударга, тэрээр бүхий л үйлстээ шударга, мөн тэрээр хүмүүний үрсэд нигүүлсэнгүй, мөн тэрээр түүний нэрэнд итгэн мөн наманчлалд нийцэх үр жимсийг авчрах хүн бүрийг аврах бүх хүчийг эзэмддэг болохыг үүрдийн ичгүүртээ хүлээн зөвшөөрөх ёстой.

16 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, тэгээд үхэл, бүр сүнсний үхэл болох хоёр дахь үхэл ирэх болно; тэгээд зуурдын үхлээр нүгэлдээ нөгчсөн хэн боловч, сүнсний үхлээр үхэх цаг болно; тийм ээ, зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд тэрээр үхэх болно.

17 Тэгээд тэдний гарчлалууд дөл нь үүрд мөн үргэлж дүрэлзэх галт мөн хүхэрт чулуун нуур лугаа адил байх цаг болно; мөн тэгээд өөрийн тааллын дагуу эзэгнэн захирах Сатаны хүч хийгээд боолчлолын дор тэд үүрдийн устгалд гинжлэгдэх болно.

18 Тиймээс, би та нарт хэлнэ, тэд гэтэлгэл огт хийгдээгүй мэт байх болно; учир нь тэд Бурханы шударга ёсны дагуу гэтэлгэгдэж чадахгүй; мөн ялзрал гэж үгүйн учир тэд үхэж ч чадахгүй болно.

19 Эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр үгсийг ярихаа төгсгөл болгоход, хүмүүс илүү ихээр гайхан цочирдож эхлэв;

Then if our hearts have been hardened, yea, if we have hardened our hearts against the word, insomuch that it has not been found in us, then will our state be awful, for then we shall be condemned.

For our words will condemn us, yea, all our works will condemn us; we shall not be found spotless; and our thoughts will also condemn us; and in this awful state we shall not dare to look up to our God; and we would fain be glad if we could command the rocks and the mountains to fall upon us to hide us from his presence.

But this cannot be; we must come forth and stand before him in his glory, and in his power, and in his might, majesty, and dominion, and acknowledge to our everlasting shame that all his judgments are just; that he is just in all his works, and that he is merciful unto the children of men, and that he has all power to save every man that believeth on his name and bringeth forth fruit meet for repentance.

And now behold, I say unto you then cometh a death, even a second death, which is a spiritual death; then is a time that whosoever dieth in his sins, as to a temporal death, shall also die a spiritual death; yea, he shall die as to things pertaining unto righteousness.

Then is the time when their torments shall be as a lake of fire and brimstone, whose flame ascendeth up forever and ever; and then is the time that they shall be chained down to an everlasting destruction, according to the power and captivity of Satan, he having subjected them according to his will.

Then, I say unto you, they shall be as though there had been no redemption made; for they cannot be redeemed according to God's justice; and they cannot die, seeing there is no more corruption.

Now it came to pass that when Alma had made an end of speaking these words, the people began to be more astonished;

- 20 Гэвч тэдний дундах ерөнхий захирагч болох Антиана гэгч нэгэн, урагшилж мөн түүнд хэлэв: Хүмүүс нас барагсдын дундаас босон мөн энэ зуурдын байдлаас үхэшгүй байдалд өөрчлөгдөнө, тиймээс, сүнс хэзээ ч үхэж чадахгүй хэмээн таны хэлсэн тэр чинь юу вэ
- 21 Анхны эцэг эхийг маань Еденийн цэцэрлэгт орон, амьдралын модны жимснээс хүртэн үүрд амьдрах вий хэмээн, Бурхан дорно хэсэгт нь херубим болон галт илд байрлуулсан хэмээн өгүүлэх судар ямар утгыг агуулна вэ? Мөн ийн тэд үүрд амьдрах боломж огт байгаагүйг бид харж байна.
- 22 Эдүгээ Алма түүнд хэлсэн нь: Энэ бол миний тайлбарлах гэж байсан зүйл. Эдүгээ Адам хориглогдсон жимснээс хүртсэнээр Бурханы үгийн дагуу унасныг бид харж байна; мөн тийн, түүний уналтаар, бүх хүн төрөлхтөн төөрөлдсөн мөн унасан хүмүүс болсныг бид харж байна.
- 23 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, тэр цагт хэрэв Адам амьдралын модны жимснээс хүртэх боломжтой байсан бол, үхэл гэж үгүй байх сан, мөн Бурханыг худалч болгох үг хүчингүй болох сон, учир нь тэрээр: Хэрэв чи идэх аваас, чи гарцаагүй үхэх болно хэмээн хэлсэн билээ.
- 24 Мөн үхэл, тийм ээ, Амюлекээр яригдсан зуурдын үхэл гэгдэх тэрхүү үхэл хүмүүн төрөлхтний дээр ирдгийг бид харж байна; гэсэн хэдий ч хүмүүн наманчилж болно хэмээн түүнд хугацаа өгөгдсөн юм; тиймийн тул энэ амьдрал нь сорилтын нөхцөл; Бурхантай уулзахаар бэлтгэх цаг; нас барагсдын амилуулалтын дараа ирэх, биднээр хэлэгдсэн тэрхүү төгсгөлгүй байдалд бэлтгэх цаг болсон ажгуу.
- 25 Эдүгээ, хэрэв дэлхийн үүслээс зэхэгдсэн гэтэлгэлийн төлөвлөгөө байгаагүй сэн бол, нас барагсдын амилуулалт гэж үгүй байх сан; гэвч яригдсан үхэгсдийн амилуулалтыг улиран тохиохоор болгох, гэтэлгэлийн төлөвлөгөө бэлтгэгдсэн билээ.
- 26 Мөн эдүгээ болгоогтун, бидний анхны эцэг эх явж мөн амьдралын модны жимснээс хүртэх боломжтой байсан бол, бэлтгэх нөхцөл гэж үгүй, тэд үүрд зовлонд байх байсан; мөн тийн гэтэлгэлийн төлөвлөгөө саатуулагдаж, мөн ямар ч үр дүнгүйн улмаас Бурханы үг хүчингүй байх байсан.

But there was one Antionah, who was a chief ruler among them, came forth and said unto him: What is this that thou hast said, that man should rise from the dead and be changed from this mortal to an immortal state, that the soul can never die?

What does the scripture mean, which saith that God placed cherubim and a flaming sword on the east of the garden of Eden, lest our first parents should enter and partake of the fruit of the tree of life, and live forever? And thus we see that there was no possible chance that they should live forever.

Now Alma said unto him: This is the thing which I was about to explain. Now we see that Adam did fall by the partaking of the forbidden fruit, according to the word of God; and thus we see, that by his fall, all mankind became a lost and fallen people.

And now behold, I say unto you that if it had been possible for Adam to have partaken of the fruit of the tree of life at that time, there would have been no death, and the word would have been void, making God a liar, for he said: If thou eat thou shalt surely die.

And we see that death comes upon mankind, yea, the death which has been spoken of by Amulek, which is the temporal death; nevertheless there was a space granted unto man in which he might repent; therefore this life became a probationary state; a time to prepare to meet God; a time to prepare for that endless state which has been spoken of by us, which is after the resurrection of the dead.

Now, if it had not been for the plan of redemption, which was laid from the foundation of the world, there could have been no resurrection of the dead; but there was a plan of redemption laid, which shall bring to pass the resurrection of the dead, of which has been spoken.

And now behold, if it were possible that our first parents could have gone forth and partaken of the tree of life they would have been forever miserable, having no preparatory state; and thus the plan of redemption would have been frustrated, and the word of God would have been void, taking none effect.

- 27 Гэвч болгоогтун, энэ нь тийм байсангүй; гэвч хүмүүнд, тэд үхэх ёстой нь тогтоогдов; мөн үхлийн дараа, тэд шүүлтэд, бүр бидний ярьсан төгсгөл болох тэрхүү шүүлтэнд ирэх ёстой.
- 28 Мөн Бурхан эдгээр зүйлийг хүмүүнд ирэхийг нь тогтоосны дараа, болгоогтун, тэгээд тэрээр тэдэнд өөрийн тогтоосон эдгээр зүйлүүдийн талаар хүмүүн мэдэх нь зайлшгүй байсныг харав;
- 29 Тиймийн тул тэдэнтэй ярилцуулахаар түүний сүр жавхланг хүмүүнд харуулах тэнгэр элчүүдийг тэрээр илгээсэн ажгуу.
- 30 Мөн тэд тэр цагаас хойшид түүний нэрийг дуудаж эхэлсэн билээ; тиймийн тул Бурхан хүмүүнтэй ярилцаж, мөн тэдэнд дэлхийн үүслээс бэлтгэгдсэн байсан гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсэн юм; мөн тэр үүнийг тэдний итгэл хийгээд наманчлал мөн тэдний ариун үйлүүдийнх нь дагуу тэдэнд мэдүүлсэн болой.
- 31 Иймийн тул, тэрээр хүмүүнд зарлигуудыг өгсөн бөлгөө, зуурдын болох зүйлүүдийн талаарх эхний зарлигуудыг тэд анх зөрчсөн учраас, мөн бурхдын адил хилэнцээс сайныг ялгаж мэдэх болж, тэд өөрсдийгөө үйлдэх байдалд тавьж, өөрөөр хэлбэл өөрсдийн таалал хийгээд хүслийн дагуу хилэнцийг эсвээс сайныг үйлдэх байдалд тавигдсан буюу—
- 32 Тиймийн тул Бурхан тэдэнд гэтэлгэлийн төлөвлөгөөг мэдүүлсний дараа тэдэнд зарлигуудыг өгсөн билээ, тэд хилэнцийг хийх ёсгүй, түүний шийтгэл нь хоёр дахь үхэл юм, зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд үүрдийнх болох тэрхүү үхэл; учир нь ийм нэгэнд гэтэлгэлийн төлөвлөгөө хүчгүй, өөрөөр хэлбэл Бурханы туйлын сайн сайхны дагуу шударга ёсны үйлүүд устгагдах боломжгүй юм.
- 33 Гэвч Бурхан өөрийн Хүүгийн нэрэнд хүмүүнийг дуудсан юм, (бэлтгэгдсэн тэр гэтэлгэлийн төлөвлөгөө нь ийм) хэлрүүн: Хэрэв та нар наманчилж мөн зүрх сэтгэлээ эс хатууруулах аваас би та нарт өөрийн Төрсөн Ганц Хүүгээр дамжуулан нигүүлсэнгүй хандах болно;

But behold, it was not so; but it was appointed unto men that they must die; and after death, they must come to judgment, even that same judgment of which we have spoken, which is the end.

And after God had appointed that these things should come unto man, behold, then he saw that it was expedient that man should know concerning the things whereof he had appointed unto them;

Therefore he sent angels to converse with them, who caused men to behold of his glory.

And they began from that time forth to call on his name; therefore God conversed with men, and made known unto them the plan of redemption, which had been prepared from the foundation of the world; and this he made known unto them according to their faith and repentance and their holy works.

Wherefore, he gave commandments unto men, they having first transgressed the first commandments as to things which were temporal, and becoming as gods, knowing good from evil, placing themselves in a state to act, or being placed in a state to act according to their wills and pleasures, whether to do evil or to do good—

Therefore God gave unto them commandments, after having made known unto them the plan of redemption, that they should not do evil, the penalty thereof being a second death, which was an everlasting death as to things pertaining unto righteousness; for on such the plan of redemption could have no power, for the works of justice could not be destroyed, according to the supreme goodness of God.

But God did call on men, in the name of his Son, (this being the plan of redemption which was laid) saying: If ye will repent, and harden not your hearts, then will I have mercy upon you, through mine Only Begotten Son;

- 34 Тиймийн тул, наманчлах мөн зүрх сэтгэлээ эс хатууруулах хэн боловч, тэрээр нүглүүдийнхээ ангижралын төлөө, миний Төрсөн Ганц Хүүгээр дамжуулан нигүүлслийг хүртэх эрхтэй болно; мөн эдгээр нь миний амралтад орох болно.
- 35 Мөн зүрх сэтгэлээ хатууруулах мөн алдсыг үйлдэх хэн боловч, болгоогтун, тэрээр миний амралтад орохгүйг бибээр уур хилэндээ андгайлна.
- 36 Мөн эдүгээ, ах дүүс минь, болгоогтун хэрэв та нар зүрх сэтгэлээ хатууруулах аваас та нар Их Эзэний амралтад орохгүйг би та нарт хэлнэ; тиймийн тул та нарын алдас, тэрээр анхны өдөөн хатгалт лугаа адил уур хилэнгээ та нарын дээр илгээх болгон түүнийг өдөөн хатгана, тийм ээ, түүний үгийн дагуу эцсийн өдөөн хатгалт эхнийх адилаар, бодгалиудын тань үүрдийн устгалд; тиймийн тул, түүний үгийн дагуу, эцсийн үхэлд эхний адилаар хүргэх буюу.
- 37 Мөн эдүгээ, ах дүүс минь, нэгэнт бид эдгээр зүйлийг мэддэг, мөн эдгээр нь үнэн учир, бид Их Эзэн Бурханаа уцаарлуулж, түүний бидэнд өгсөн эдгээр хоёр дахь зарлигуудын хувьд хилэгнэлээ бидний дээр доош илгээхгүйн тулд наманчилцгаая мөн зүрх сэтгэлээ үл хатууруулцгаая; харин түүний үгийн дагуу бэлтгэгдсэн Бурханы амралтад орцгооё.

Therefore, whosoever repenteth, and hardeneth not his heart, he shall have claim on mercy through mine Only Begotten Son, unto a remission of his sins; and these shall enter into my rest.

And whosoever will harden his heart and will do iniquity, behold, I swear in my wrath that he shall not enter into my rest.

And now, my brethren, behold I say unto you, that if ye will harden your hearts ye shall not enter into the rest of the Lord; therefore your iniquity provoketh him that he sendeth down his wrath upon you as in the first provocation, yea, according to his word in the last provocation as well as the first, to the everlasting destruction of your souls; therefore, according to his word, unto the last death, as well as the first.

And now, my brethren, seeing we know these things, and they are true, let us repent, and harden not our hearts, that we provoke not the Lord our God to pull down his wrath upon us in these his second commandments which he has given unto us; but let us enter into the rest of God, which is prepared according to his word.



## Алма 13

- 1 Мөн түүнчлэн, ах дүүс минь, Их Эзэн Бурхан өөрийн хүүхдүүдэд эдгээр зарлигийг өгсөн тэр цаг тийш би та нарын оюун санааг хандуулмаар байна; мөн Их Эзэн Бурхан өөрийн Хүүгийн жаягийн дагуу ариун жаягийнхаа дагуу хүмүүст эдгээр зүйлийг заах санваартнуудыг томилсныг та нар санаасай хэмээнэ би.
- 2 Мөн тэдгээр санваартнууд, хүмүүс түүний Хүүгийн гэтэлгэлийг ямар маягаар хүсэн хүлээхийг мэдэж болох тийм маягаар түүний Хүүгийн жаягийн дагуу томилогдсон билээ.
- 3 Мөн тэдний томилогдсон тэр маяг нь энэ буюу—Бурханы зөгнөх мэдлэгийн дагуу тэдний үлэмжийн итгэл хийгээд сайн үйлүүдээс үндэслэн дэлхийн үүслээс дуудагдсан мөн бэлтгэгдсэн билээ; эхнээсээ сайныг эсвээс хилэнцийг сонгохоор үлдээгдсэн ажгуу; тиймийн тул тэд сайныг сонгосны учир, мөн үлэмж агуу итгэлийг бодитой болгосон учир, тэд ариун дуудлагад, тийм ээ, ийм хүмүүсийн тул гэтэлгэл бэлтгэгдсэний дагуу мөн түүнтэй нэгэн цагт бэлтгэгдсэн тэрхүү ариун дуудлагуудаар дуудагдсан ажээ.
- 4 Мөн тийн тэд итгэлийнхээ учир энэ ариун дуудлагад дуудагдсан билээ, гэтэл бусад зарим нь зүрх сэтгэл нь хатуугийн мөн оюун нь харалганы учир Бурханы Сүнсийг эсэргүүцдэг, харин хэрэв ийм байгаагүй аваас өөрсдийнх нь ах дүүсийн адил тэдэнд агуу боломж байж болох байсан.
- 5 Өөрөөр хэлбэл эцэст нь, эхнээсээ тэд ах дүүстэйгээ хамт адил байдалд байв; тийн энэ ариун дуудлага дэлхийн үүслээс зүрх сэтгэлээ үл хатууруулах иймүүдэд зориулан бэлтгэгдсэн нь, бэлтгэгдсэн тэр болох Төрсөн Ганц Хүүгийн цагаатгал үүнд мөн үүгээр байх бөлгөө—
- 6 Мөн тийн тэд ч бас түүний амралтад орж болохын тулд хүмүүний үрсэд түүний зарлигуудыг заахаар энэхүү ариун дуудлагаар дуудагдаж, мөн Бурханы ариун жаягийн дээд санваарт томилогдсон буюу—

## Alma 13

And again, my brethren, I would cite your minds forward to the time when the Lord God gave these commandments unto his children; and I would that ye should remember that the Lord God ordained priests, after his holy order, which was after the order of his Son, to teach these things unto the people.

And those priests were ordained after the order of his Son, in a manner that thereby the people might know in what manner to look forward to his Son for redemption.

And this is the manner after which they were ordained—being called and prepared from the foundation of the world according to the foreknowledge of God, on account of their exceeding faith and good works; in the first place being left to choose good or evil; therefore they having chosen good, and exercising exceedingly great faith, are called with a holy calling, yea, with that holy calling which was prepared with, and according to, a preparatory redemption for such.

And thus they have been called to this holy calling on account of their faith, while others would reject the Spirit of God on account of the hardness of their hearts and blindness of their minds, while, if it had not been for this they might have had as great privilege as their brethren.

Or in fine, in the first place they were on the same standing with their brethren; thus this holy calling being prepared from the foundation of the world for such as would not harden their hearts, being in and through the atonement of the Only Begotten Son, who was prepared—

And thus being called by this holy calling, and ordained unto the high priesthood of the holy order of God, to teach his commandments unto the children of men, that they also might enter into his rest—

- 7 Энэхүү дээд санваар нь дэлхийн үүслээс байсан жаяг болох түүний Хүүгийн жаягийн дагуу билээ; эсвээс өөр үгсээр бол, өдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөлгүйгээр бүх зүйлийг зөгнөх мэдлэгийнх нь дагуу, үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд бэлтгэгдсэн билээ—
- 8 Эдүгээ тэд энэ маягаар томилогдсон ажгуу— ариун дуудлагаар дуудагдаж, мөн ариун ёслолоор томилогдож, мөн ариун жаягийн дээд санваарыг тэд өөрсдийнхөө дээр авах, энэхүү дуудлага хийгээд ёслол, мөн дээд санваар нь эхлэл бас төгсгөлгүй болой—
- 9 Ач ивээл, тэгш байдал, мөн үнэн байдлаар дүүрэн, өдрүүдийн эхлэл буюу жилүүдийн төгсгөлгүй, Эцэгийн Төрсөн Ганц болох, Хүүгийн жаягийн дагуу тэд тийн үүрд дээд санваартнууд болдог. Мөн тийн байх болой. Амен.
- 10 Эдүгээ, ариун жаяг, өөрөөр хэлбэл энэхүү дээд санваарын талаар миний хэлснээр, томилогдож мөн Бурханы дээд санваартан болсон нь олон байв; мөн энэ нь тэдний үлэмж итгэл хийгээд наманчлал, мөн Бурханы өмнөх тэдний зөв шударга байдлаас нь үндэслэсэн байв, мөхөхийн оронд наманчлан мөн зөв шударгыг үйлдэхийг тэд сонгосны учир буюу;
- 11 Тиймийн тул тэд энэ ариун жаягийн дагуу дуудагдаж мөн ариусгагдан, мөн тэдний өмсгөлүүд Хурганы цусаар угаагдан цагаан болсон юм.
- 12 Эдүгээ тэд, Ариун Сүнсээр ариусгагдсаны дараа, тэдний өмсгөлүүд цагаан болгогдсон учир, тэд Бурханы өмнө цэвэр мөн толбогүй байсан учир, жигшлээс өөрөөр нүглийг үзэж эс чадна; мөн цэвэршигдэж мөн Их Эзэн Бурханыхаа амралтад орсон нь олон, үлэмж олон байв.
- 13 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар өөрсдийгөө Бурханы өмнө даруусгаж, мөн та нар түүнчлэн уг амралтад орж болохын тулд наманчлалд нийцэх үр жимсийг та нар гаргаасай хэмээнэ би.
- 14 Тийм ээ, бүр миний ярьсан жаягийн дагуу дээд санваартан асан, түүнчлэн өөр дээрээ дээд санваарыг үүрд авсан Мелкизедекийн өдрүүд дэх хүмүүсийн адил өөрсдийгөө даруусга.

This high priesthood being after the order of his Son, which order was from the foundation of the world; or in other words, being without beginning of days or end of years, being prepared from eternity to all eternity, according to his foreknowledge of all things—

Now they were ordained after this manner—being called with a holy calling, and ordained with a holy ordinance, and taking upon them the high priesthood of the holy order, which calling, and ordinance, and high priesthood, is without beginning or end—

Thus they become high priests forever, after the order of the Son, the Only Begotten of the Father, who is without beginning of days or end of years, who is full of grace, equity, and truth. And thus it is. Amen.

Now, as I said concerning the holy order, or this high priesthood, there were many who were ordained and became high priests of God; and it was on account of their exceeding faith and repentance, and their righteousness before God, they choosing to repent and work righteousness rather than to perish;

Therefore they were called after this holy order, and were sanctified, and their garments were washed white through the blood of the Lamb.

Now they, after being sanctified by the Holy Ghost, having their garments made white, being pure and spotless before God, could not look upon sin save it were with abhorrence; and there were many, exceedingly great many, who were made pure and entered into the rest of the Lord their God.

And now, my brethren, I would that ye should humble yourselves before God, and bring forth fruit meet for repentance, that ye may also enter into that rest.

Yea, humble yourselves even as the people in the days of Melchizedek, who was also a high priest after this same order which I have spoken, who also took upon him the high priesthood forever.

15 Мөн энэ нь Абрахам түүнд аравны нэгийг төлдөг асан Мелкизедек байв; тийм ээ, бүр бидний эцэг Абрахам өөрийн бүх эзэмшсэний аравны нэгийг төлдөг байсан билээ.

16 Эдүгээ эдгээр ёслолууд, үүгээр хүмүүс Бурханы Хүүг хүсэн хүлээж болохын тулд энэ маягаар өгөгдсөн аж, мөн энэ нь түүний жаягийн дүрслэл, өөрөөр хэлбэл энэ нь түүний жаяг, мөн энэ нь тэд нүглүүдийнхээ ангижралын тулд түүнийг харуулдан хүлээж болохын тулд, тэд Их Эзэний амралтад орж болохын тулд хийгдсэн билээ.

17 Эдүгээ энэхүү Мелкизедек нь Салем нутгийн хаан байв; мөн түүний хүмүүс алдас мөн жигшүүрт хэргүүдийн хувьд хүчирхэгжсэн байв; тийм ээ, тэд бүгд төөрч одсон байв; тэд бүх төрлийн ёсон бусаар дүүрэн байв;

18 Гэвч Мелкизедек хүчит итгэлийг бодитой болгож, мөн Бурханы ариун жаягийн дагуу дээд санваарын албан тушаалыг хүлээн авсны учир, өөрийн хүмүүст наманчлалыг номлосон ажгуу. Мөн болгоогтун, тэд наманчилжээ; мөн Мелкизедек өөрийн өдрүүдэд уг нутагт амар амгаланг тогтоов; тиймийн тул тэрээр энх амгалангийн ханхүү гэж нэрлэгдсэн бөлгөө, учир нь тэр Салемын хаан байв; мөн тэрээр эцгийнхээ захиргаан дор засаглаж байв.

19 Эдүгээ, түүнээс өмнө олон нь байж, мөн түүнчлэн дараа нь ч олон байв, гэвч илүү агуу нь үгүй байлаа; тиймийн тул, тэд түүний тухай илүү чухалчлан дурдсан бөлгөө.

20 Эдүгээ би энэ хэргийг нарийвчлан ярих хэрэггүй; миний хэлсэн нь хангалттай. Болгоогтун, судрууд та нарын өмнө байна; хэрэв та нар тэдгээрийг мушгин гуйвуулах аваас энэ нь та нарыг устгалд тань хүргэх болно.

21 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр үгсийг тэдэнд хэлээд, тэрээр тэдний зүг гараа сунган мөн хүчирхэг хоолойгоор хашгирч, хэлрүүн: Наманчлах цаг нь одоо болой, учир нь авралын өдөр ойртож байна;

And it was this same Melchizedek to whom Abraham paid tithes; yea, even our father Abraham paid tithes of one-tenth part of all he possessed.

Now these ordinances were given after this manner, that thereby the people might look forward on the Son of God, it being a type of his order, or it being his order, and this that they might look forward to him for a remission of their sins, that they might enter into the rest of the Lord.

Now this Melchizedek was a king over the land of Salem; and his people had waxed strong in iniquity and abomination; yea, they had all gone astray; they were full of all manner of wickedness;

But Melchizedek having exercised mighty faith, and received the office of the high priesthood according to the holy order of God, did preach repentance unto his people. And behold, they did repent; and Melchizedek did establish peace in the land in his days; therefore he was called the prince of peace, for he was the king of Salem; and he did reign under his father.

Now, there were many before him, and also there were many afterwards, but none were greater; therefore, of him they have more particularly made mention.

Now I need not rehearse the matter; what I have said may suffice. Behold, the scriptures are before you; if ye will wrest them it shall be to your own destruction.

And now it came to pass that when Alma had said these words unto them, he stretched forth his hand unto them and cried with a mighty voice, saying: Now is the time to repent, for the day of salvation draweth nigh;

22 Тийм ээ, мөн Их Эзэний дуу хоолой, тэнгэр элчүүдийн амаар, үүнийг бүх үндэстнүүдэд тунхагладаг; тийм ээ, тэд агуу их баяслын баярт мэдээг мэдэж болохын тулд үүнийг тунхагладаг; тийм ээ, мөн тэрээр эдгээр баярт мэдээг өөрийн бүх хүмүүсийн дунд, тийм ээ, бүр газрын гадаргуугаар тарсан тэдэнд сонсгодог; иймийн тул тэдгээр нь бидэнд ирсэн бөлгөө.

23 Мөн тэдгээр нь бид ойлгож болохын тулд, бид алдаж чадахгүйгээр тодорхой үгээр бидэнд мэдүүлэгдсэн билээ; мөн энэ нь бид харь нутагт хэсэн бэдрэгчид болохын учир юм; тиймийн тул, бид тийн өндрөөр үнэлэгдсэн, учир нь өөрсдийн маань талбайн бүх хэсгүүдэд эдгээр баярт мэдээ бидэнд тунхаглагдан өгөгдсөн юм.

24 Учир нь болгоогтун, тэнгэр элчүүд манай нутагт энэ цагт үүнийг олонд тунхаглаж байна; мөн энэ нь тэрээр өөрийн алдар суугаар ирэх тэр цагт түүний үгийг хүлээн авахад хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг бэлтгэх зорилготой ажгуу.

25 Мөн эдүгээ түүний ирэх тухай тэнгэр элчүүдийн амаар бидэнд зарлагдах баярт мэдээг зөвхөн сонсохыг бид хүлээсэн бөлгөө; учир нь тэр цаг ирнэ, хэр ойрхон болохыг нь бид мэдэхгүй. Энэ нь миний өдрүүдэд байх болоосой хэмээн Бурханд хандана; гэсэн ч энэ нь даруйхан эсвэл хожим ч бай, би үүнд баясах болно.

26 Мөн энэ нь түүний ирэлтийн цагт тэнгэр элчүүдийн амаар шударга бөгөөд ариун хүмүүст мэдүүлэгдэх болно, тэдэнд байсан бошиглолын суу билгийн дагуу, түүний талаар тэдний ярьсны дагуу, бидний эцэг өвгөдийн үгс гүйцэлдэж болохын тулд болой.

27 Мөн эдүгээ, ах дүүс минь, зүрхнийхээ угаас, тийм ээ, бүр өвдөлтийг мэдрэх агуу зовнилоор, та нар миний үгсийг сонсоосой, мөн нүглүүдээсээ салаасай, мөн наманчлалынхаа өдрийг бүү хойшлуулаасай хэмээн хүснэ би;

Yea, and the voice of the Lord, by the mouth of angels, doth declare it unto all nations; yea, doth declare it, that they may have glad tidings of great joy; yea, and he doth sound these glad tidings among all his people, yea, even to them that are scattered abroad upon the face of the earth; wherefore they have come unto us.

And they are made known unto us in plain terms, that we may understand, that we cannot err; and this because of our being wanderers in a strange land; therefore, we are thus highly favored, for we have these glad tidings declared unto us in all parts of our vineyard.

For behold, angels are declaring it unto many at this time in our land; and this is for the purpose of preparing the hearts of the children of men to receive his word at the time of his coming in his glory.

And now we only wait to hear the joyful news declared unto us by the mouth of angels, of his coming; for the time cometh, we know not how soon. Would to God that it might be in my day; but let it be sooner or later, in it I will rejoice.

And it shall be made known unto just and holy men, by the mouth of angels, at the time of his coming, that the words of our fathers may be fulfilled, according to that which they have spoken concerning him, which was according to the spirit of prophecy which was in them.

And now, my brethren, I wish from the inmost part of my heart, yea, with great anxiety even unto pain, that ye would hearken unto my words, and cast off your sins, and not procrastinate the day of your repentance;

- 28 Харин та нар Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, түүний ариун нэрийг дуудаж, мөн та нар өөрсдийн үүрч чадахаас илүүгээр уруу таталтанд автагдахгүйн тулд үргэлж сэрэмжилж мөн залбираасай, тэгснээр Ариун Сүнсээр удирдуулан, даруухан, дөлгөөн, хүлцэнгүй, гэвчээртэй, хайр хийгээд бүхийл тэсвэрээр дүүрэн болоосой;
- 29 Их Эзэнд итгэх итгэлтэй байгаасай; та нар мөнх амьдралыг хүлээн авах болно гэсэн найдварыг агуулаасай; та нар эцсийн өдөр өргөгдөн мөн түүний амралтад орж болохын тул зүрх сэтгэлдээ Бурханы хайрыг үргэлж тээгээсэй хэмээнэ.
- 30 Мөн та нар түүний хилэнг өөрсдийн дээр доош авчрахгүй байж болохын тулд, та нар тамын гинжээр хүлэгдэхгүй байж болохын тулд, та нар хоёрдахь үхлийг амсахгүй байж болохын тулд Их Эзэн та нарт наманчлалыг соёрхох болтугай.
- 31 Мөн Алма энэ номонд бичигдээгүй өөр олон үгсийг хүмүүст ярьсан билээ.

But that ye would humble yourselves before the Lord, and call on his holy name, and watch and pray continually, that ye may not be tempted above that which ye can bear, and thus be led by the Holy Spirit, becoming humble, meek, submissive, patient, full of love and all long-suffering;

Having faith on the Lord; having a hope that ye shall receive eternal life; having the love of God always in your hearts, that ye may be lifted up at the last day and enter into his rest.

And may the Lord grant unto you repentance, that ye may not bring down his wrath upon you, that ye may not be bound down by the chains of hell, that ye may not suffer the second death.

And Alma spake many more words unto the people, which are not written in this book.

## Алма 14

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүст ярихаа төгсгөл болгосны дараа тэдний олон нь түүний үгсэд итгэсэн болой, мөн наманчилж, мөн судруудыг судалж эхлэв.
- 2 Гэвч тэдний ихэнх хэсэг нь Алма Амюлек хоёрыг тэд устгаж болно хэмээх хүсэлтэй байв; учир нь Зиезромд хандсан түүний үгс тодорхойн учир тэд Алмад уурлаж байв; мөн түүнчлэн Амюлек тэдэнд худал хэлж, мөн тэдний хуулийг мөн түүнчлэн тэдний хуульчид болоод шүүгчдийг эсэргүүцэн доромжилсон хэмээн тэд хэлж байв.
- 3 Мөн түүнчлэн Алма Амюлек хоёрт тэд уурлаж байв; мөн тэд өөрсдийнх нь ёс бусын эсрэг тийм тодорхойгоор гэрчилсэн учир, тэднийг нууцаар үгүй хийхийг тэд эрэлхийлж байв.
- 4 Гэвч улиран тохиох дор тэд тэгсэнгүй; гэвч тэд тэднийг баривчлан мөн тэднийг бөх олсоор хүлж, мөн нутгийн ерөнхий шүүгчийн өмнө тэднийг аваачив.
- 5 Мөн хүмүүс урагшилж мөн тэдний эсрэг гэрчлэв—тэд хуулийг, мөн нутгийн хуульчид хийгээд шүүгчдийг, мөн түүнчлэн уг нутагт байсан бүх хүмүүсийг доромжилсныг мэдүүлэв; мөн түүнчлэн ганцхан Бурхан буй, мөн тэрээр өөрийн Хүүг хүмүүсийн дунд илгээх боловч, тэр нь тэднийг үл аврах болно хэмээн гэрчилснийг; мөн олон иймэрхүү зүйлийг Алма Амюлек хоёрын эсрэг хүмүүс гэрчлэв. Эдүгээ энэ нь уг нутгийн ерөнхий шүүгчийн өмнө болов.
- 6 Мөнхүү улиран тохиох дор Зиезром яригдсан тэр үгсэд гайхсан ажгуу; мөн тэрээр түүнчлэн худал үгсээрээ хүмүүсийн дунд өөрийн бий болгосон оюун санааных нь харалган байдлын талаар мэджээ; мөн тэрээр өөрийн гэмийг ухамсарласнаар түүний бодгаль тарчилж эхлэв; тийм ээ, тэрээр тамын шаналлаар хүрээлэгдэж эхлэв.

## Alma 14

And it came to pass after he had made an end of speaking unto the people many of them did believe on his words, and began to repent, and to search the scriptures.

But the more part of them were desirous that they might destroy Alma and Amulek; for they were angry with Alma, because of the plainness of his words unto Zeezrom; and they also said that Amulek had lied unto them, and had reviled against their law and also against their lawyers and judges.

And they were also angry with Alma and Amulek; and because they had testified so plainly against their wickedness, they sought to put them away privily.

But it came to pass that they did not; but they took them and bound them with strong cords, and took them before the chief judge of the land.

And the people went forth and witnessed against them—testifying that they had reviled against the law, and their lawyers and judges of the land, and also of all the people that were in the land; and also testified that there was but one God, and that he should send his Son among the people, but he should not save them; and many such things did the people testify against Alma and Amulek. Now this was done before the chief judge of the land.

And it came to pass that Zeezrom was astonished at the words which had been spoken; and he also knew concerning the blindness of the minds, which he had caused among the people by his lying words; and his soul began to be harrowed up under a consciousness of his own guilt; yea, he began to be encircled about by the pains of hell.

7 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүст хашгирч эхлэн, хэлсэн нь: Болгоогтун, би бол гэмтэй, мөн эдгээр хүмүүс Бурханы өмнө толбогүй. Мөн тэрээр тэр цагаас хойш тэдний өмнөөс гуйж эхлэв; гэвч тэд түүнийг доромжилж хэлсэн нь: Та түүнчлэн чөтгөрт эзлэгдчихэв үү? Мөн тэд түүн дээр нулимж, мөн түүнийг, мөн түүнчлэн Алма, Амюлек нараар яригдсан үгсэд итгэсэн тэд бүгдийг өөрсдийнхөө дундаас зайлуулав; мөн тэд тэднийг зайлуулж, мөн тэдний зүг чулуу шидүүлэхээр хүмүүсийг илгээв.

8 Мөн тэд эхнэр болон хүүхдүүдийг нь хамтад нь авчирч, мөн Бурханы үгэнд итгэсэн эсвэл итгэхээр заалгасан хэнийг боловч тэднийг галд хаягдахаар болгов; мөн түүнчлэн тэд ариун судруудыг тээсэн цэдгүүдийг авчирч, тэдгээр нь галд шатаагдаж мөн устгагдаж болохын тулд тэдгээрийг түүнчлэн галд хаяв.

9 Мөнхүү улиран тохиох дор тэд Алма, Амюлек хоёрыг барьж, мөн тэд галд үрэгдсэн тэдний устгалыг үзэж болохын тулд тэднийг цаазын газарт аваачив.

10 Мөн галд үрэгдэж буй эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн зовлонг Амюлек хараад, тэрээр түүнчлэн шаналав; мөн тэр Алмад хэлэв: Бид энэ аймшигт явдлыг харж яахан чадах билээ? Тиймийн тул гараа сунгацгаая, мөн бидэнд буй Бурханы хүчийг үзүүлж, мөн тэднийг дөлнөөс аварцгаая.

11 Гэвч Алма түүнд хэлэв: Сүнс намайг гараа сунгах ёсгүй хэмээн албадаж байна; учир нь болгоогтун Их Эзэн тэднийг өөртөө алдар суугаар хүлээн авах болно; өөрийн хилэгнэлд тэдний дээр үзүүлэх шүүлтүүд шударга байж болохын тулд, хүмүүс зүрх сэтгэлийнхээ хатуу байдлын дагуу тэдэнд энэ зүйлийг хийж болохыг, өөрөөр хэлбэл тэд энэ зүйлийг хийж болохыг тэрээр зөвшөөрөх болно; мөн гэм зэмгүй хүмүүсийн цус тэдний эсрэг гэрч болон зогсох болно, тийм ээ, мөн эцсийн өдөр тэдний эсрэг хүчтэйгээр хашгирах болно.

12 Эдүгээ Амюлек Алмад хэлэв: Болгоогтун, магадгүй тэд түүнчлэн биднийг ч шатаах болно.

13 Мөн Алма хэлэв: Энэ нь Их Эзэний тааллын дагуу байг. Гэвч, болгоогтун, бидний ажил дуусаагүй байна; тиймийн тул тэд биднийг шатаахгүй.

And it came to pass that he began to cry unto the people, saying: Behold, I am guilty, and these men are spotless before God. And he began to plead for them from that time forth; but they reviled him, saying: Art thou also possessed with the devil? And they spit upon him, and cast him out from among them, and also all those who believed in the words which had been spoken by Alma and Amulek; and they cast them out, and sent men to cast stones at them.

And they brought their wives and children together, and whosoever believed or had been taught to believe in the word of God they caused that they should be cast into the fire; and they also brought forth their records which contained the holy scriptures, and cast them into the fire also, that they might be burned and destroyed by fire.

And it came to pass that they took Alma and Amulek, and carried them forth to the place of martyrdom, that they might witness the destruction of those who were consumed by fire.

And when Amulek saw the pains of the women and children who were consuming in the fire, he also was pained; and he said unto Alma: How can we witness this awful scene? Therefore let us stretch forth our hands, and exercise the power of God which is in us, and save them from the flames.

But Alma said unto him: The Spirit constraineth me that I must not stretch forth mine hand; for behold the Lord receiveth them up unto himself, in glory; and he doth suffer that they may do this thing, or that the people may do this thing unto them, according to the hardness of their hearts, that the judgments which he shall exercise upon them in his wrath may be just; and the blood of the innocent shall stand as a witness against them, yea, and cry mightily against them at the last day.

Now Amulek said unto Alma: Behold, perhaps they will burn us also.

And Alma said: Be it according to the will of the Lord. But, behold, our work is not finished; therefore they burn us not.

14 Эдүгээ улиран тохиох дор галд хаягдсан тэдний биес үрэгдэв, мөн түүнчлэн тэдэнтэй хаягдсан цэдгүүд ч бас үрэгдсэний дараа, нутгийн ерөнхий шүүгч ирж, мөн тэднийг хүлээстэй байхад нь Алма, Амюлек хоёрын өмнө зогсов; мөн тэр тэднийг гараараа хацар дээр нь цохиж, мөн тэдэнд хэлэв: Та нар үзсэн үүнийхээ дараа, галан мөн хүхэрт чулуун нууранд хаягдах болно хэмээн энэ хүмүүст дахин номлох уу

15 Болгоогтун, та нар галд хаягдсан тэднийг аврах хүчгүй байснаа харж байна; бас та нарын бишрэлд нэгдлээ гээд Бурхан ч тэднийг аварсангүй. Мөнхүү шүүгч тэднийг дахин хацар дээр нь цохиж, мөн асуув: Та нар өөрсдийнхөө төлөө юу хэлэх вэ

16 Эдүгээ энэ шүүгч, Гидеоныг алсан Нихорын жаяг мөн бишрэлийн дагуу байв.

17 Мөнхүү улиран тохиох дор Алма Амюлек хоёр түүнд юу ч хариулсангүй; мөн тэр тэднийг дахин цохиж, мөн тэднийг шоронд хийлгэхээр албатуудад шилжүүлэв.

18 Мөн тэд шоронд гурав хоног хоригдсоны дараа, Нихорын адил бодолтой байсан олон хуульчид хийгээд шүүгчид мөн санваартнууд мөн багш нар ирэв; мөн тэд шоронд тэднийг харахаар ирж мөн олон үгсийн талаар тэднийг шалгаав; гэвч тэд тэдэнд юу ч хариулсангүй.

19 Мөнхүү улиран тохиох дор уг шүүгч тэдний өмнө зогсоод, мөн хэлэв: Та нар яагаад энэ хүмүүсийн үгсэд хариулахгүй байна? Та нарыг дөлөнд илгээх хүч надад буйг та нар мэдэхгүй гэж үү? Мөн тэрээр тэдэнд ярихыг зарлиглав; гэвч тэд юу ч хариулсангүй.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд одож мөн өөрсдийнхөө замаар явцгаав, гэвч маргааш нь дахин ирэв; мөн шүүгч түүнчлэн тэднийг хацар дээр нь дахин цохив. Мөн түүнчлэн олон нь дөхөн очиж, мөн тэднийг цохиж, хэлрүүн: Та нар дахин босож мөн энэ хүмүүсийг шүүж, мөн хуулийг маань буруушаах уу? Хэрэв та нарт тийм их хүч буй аваас та нар өөрсдийгөө яагаад чөлөөлөхгүй байна

21 Мөн тэд олон тийм зүйлийг тэдэнд хэлж, шүдээ хавирцгааж, мөн тэдний дээр нулимж, мөн хэлрүүн: Бид яллагдсан үедээ ямар харагдах бол

Now it came to pass that when the bodies of those who had been cast into the fire were consumed, and also the records which were cast in with them, the chief judge of the land came and stood before Alma and Amulek, as they were bound; and he smote them with his hand upon their cheeks, and said unto them: After what ye have seen, will ye preach again unto this people, that they shall be cast into a lake of fire and brimstone?

Behold, ye see that ye had not power to save those who had been cast into the fire; neither has God saved them because they were of thy faith. And the judge smote them again upon their cheeks, and asked: What say ye for yourselves?

Now this judge was after the order and faith of Nehor, who slew Gideon.

And it came to pass that Alma and Amulek answered him nothing; and he smote them again, and delivered them to the officers to be cast into prison.

And when they had been cast into prison three days, there came many lawyers, and judges, and priests, and teachers, who were of the profession of Nehor; and they came in unto the prison to see them, and they questioned them about many words; but they answered them nothing.

And it came to pass that the judge stood before them, and said: Why do ye not answer the words of this people? Know ye not that I have power to deliver you up unto the flames? And he commanded them to speak; but they answered nothing.

And it came to pass that they departed and went their ways, but came again on the morrow; and the judge also smote them again on their cheeks. And many came forth also, and smote them, saying: Will ye stand again and judge this people, and condemn our law? If ye have such great power why do ye not deliver yourselves?

And many such things did they say unto them, gnashing their teeth upon them, and spitting upon them, and saying: How shall we look when we are damned?



22 Мөн олон тийм зүйл, тийм ээ, тэд бүх л төрлийн ийм зүйлийг тэдэнд хэлсэн болой; мөн тийн тэд олон хоногийн турш тэднийг дооглов. Мөн тэд өлсөж болохын тулд тэдэнд хүнс, мөн тэд цангаж болохын тулд ус өгөхөөс татгалзсан болой; мөн түүнчлэн хувцсыг нь тэднээс авсан учир тэд нүцгэн байв; мөн тийн тэд бөх олсоор хүлүүлж, мөн шоронд хоригдов.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд олон хоногийн турш тийн зовсны дараа, (мөн энэ нь Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арав дахь онд, аравдугаар сарын, арванхоёр дахь өдөр байв) олсоор хүлэгдсэн Алма, Амюлек нарын байгаа шоронд, Аммонайхагийн нутгийн ерөнхий шүүгч мөн тэдний багш нарын мөн тэдний хуульчдын олон нь очив.

24 Мөн ерөнхий шүүгч тэдний өмнө зогсоод, мөн тэднийг дахин цохиж, мөн тэдэнд хэлэв: Хэрэв Бурханы хүч та нарт байвал энэ хүлээснээс өөрсдийгөө чөлөөлөөч, мөн тэгвэл та нарын үгсийн дагуу Их Эзэн энэ хүмүүсийг устгах болно гэдэгт бид итгэх болно.

25 Мөнхүү улиран тохиох дор бүр сүүлчийнх нь хүртэл, тэд бүгд урагш дөхөн мөн тэднийг цохиж, нэгэн адил үгсийг хэлэв; мөн сүүлчийнх нь тэдэнд ярьсны дараа Бурханы хүч Алма Амюлек хоёр дээр байж, мөн тэд босож мөн хөл дээрээ зогсоцгоов.

26 Мөн Алма хашгирч, хэлрүүн: Бид энэ аймшигт зүдрэлүүдийг хэр удаан хүлцэх билээ, Ай Их Эзэн? Ай Их Эзэн, Христэд итгэх бидний итгэлийн дагуу, бүр чөлөөлөгдөх хүртэл бидэнд хүчийг өгөөч. Мөн тэд хүлэгдсэн олсоо тасчив; мөн хүмүүс үүнийг хараад, устгалаас айх айдас тэдэн дээр ирсэн учир зугтаж эхлэв.

27 Мөнхүү улиран тохиох дор тэдний айдас агуу байсан учир тэд хөсөр унаж, мөн шоронгийн гадаах хаалганд хүрсэнгүй; мөн газар хүчтэйгээр чичирч, мөн шоронгийн хана хоёр хэсэгт хуваагдан цуурч, иймээс тэд газарт унав; мөн Алма Амюлек хоёрыг цохиж байсан ерөнхий шүүгч, мөн хуульчид, мөн санваартнууд, мөн багш нар үүний нурангид алагдав.

And many such things, yea, all manner of such things did they say unto them; and thus they did mock them for many days. And they did withhold food from them that they might hunger, and water that they might thirst; and they also did take from them their clothes that they were naked; and thus they were bound with strong cords, and confined in prison.

And it came to pass after they had thus suffered for many days, (and it was on the twelfth day, in the tenth month, in the tenth year of the reign of the judges over the people of Nephi) that the chief judge over the land of Ammonihah and many of their teachers and their lawyers went in unto the prison where Alma and Amulek were bound with cords.

And the chief judge stood before them, and smote them again, and said unto them: If ye have the power of God deliver yourselves from these bands, and then we will believe that the Lord will destroy this people according to your words.

And it came to pass that they all went forth and smote them, saying the same words, even until the last; and when the last had spoken unto them the power of God was upon Alma and Amulek, and they rose and stood upon their feet.

And Alma cried, saying: How long shall we suffer these great afflictions, O Lord? O Lord, give us strength according to our faith which is in Christ, even unto deliverance. And they broke the cords with which they were bound; and when the people saw this, they began to flee, for the fear of destruction had come upon them.

And it came to pass that so great was their fear that they fell to the earth, and did not obtain the outer door of the prison; and the earth shook mightily, and the walls of the prison were rent in twain, so that they fell to the earth; and the chief judge, and the lawyers, and priests, and teachers, who smote upon Alma and Amulek, were slain by the fall thereof.

28 Мөн Алма, Амюлек хоёр шоронгоос гарч ирэв, мөн тэд гэмтээгүй байв; учир нь Христэд итгэх итгэлийнх нь дагуу Их Эзэн тэдэнд хүчийг соёрхсон ажээ. Мөн тэд тэр даруй шоронгоос гарч ирэв; мөн тэд хүлээснээсээ мултарсан байв; мөн шорон газарт нуран унасан байв, мөн дотор нь байсан бодгаль бүр, Алма, Амюлек хоёроос бусад нь алагдав; мөн тэд тэр даруй хотод ирэв.

29 Эдүгээ их чимээг сонсоод хүмүүс хэсэг хэсгээрээ хамтдаа үүний шалтгааныг мэдэхээр гүйлдэж ирэв; мөн тэд Алма Амюлек хоёр шоронгоос гарч ирж буйг, мөн үүний хана газарт нурсныг хараад, тэд ихэд айж цочин, мөн Алма Амюлек хоёрын дэргэдээс бүр ямаа төлөө аван хоёр арслангаас зугтах лугаа адил зугтав; мөн тийн тэд Алма Амюлек хоёрын дэргэдээс зугтсан болой.

And Alma and Amulek came forth out of the prison, and they were not hurt; for the Lord had granted unto them power, according to their faith which was in Christ. And they straightway came forth out of the prison; and they were loosed from their bands; and the prison had fallen to the earth, and every soul within the walls thereof, save it were Alma and Amulek, was slain; and they straightway came forth into the city.

Now the people having heard a great noise came running together by multitudes to know the cause of it; and when they saw Alma and Amulek coming forth out of the prison, and the walls thereof had fallen to the earth, they were struck with great fear, and fled from the presence of Alma and Amulek even as a goat fleeth with her young from two lions; and thus they did flee from the presence of Alma and Amulek.

## Алма 15

- 1 Мөнхүү улиран тохиох дор Алма, Амюлек хоёр тэр хотоос одохыг зарлигдуулав; мөн тэд одож, мөн бүр Сайдомын нутагт хүрч ирэв; мөн болгоогтун, тэнд Аммонайхагийн нутгаас тэд Алмагийн үгсэд итгэснийхээ учир хөөгдөж мөн чулуугаар шидүүлэн зайлж одсон бүх хүмүүсийг тэд олов.
- 2 Мөн тэд бүгдэд эхнэр мөн хүүхдүүдэд нь юу тохиолдсоныг, мөн түүнчлэн өөрсдийнхөө талаар, мөн өөрсдийн чөлөөлөлтийн хүчний тухай тэдэнд өгүүлэв.
- 3 Мөн түүнчлэн Зиезром өөрийнх нь ёс бусаас үүдсэн оюун санааны их зүдрэлээс болоод ихэд халууран Сайдомд өвчтэй хэвтэж байв, учир нь тэр Алма, Амюлек хоёрыг үгүй болсон хэмээн бодсон аж; мөн тэд өөрсдийн алдсын улмаас алагдсан хэмээн бодсон байв. Мөн энэ их нүгэл, мөн түүний бусад олон нүгэл, түүний оюуныг мултрах аргагүй, үлэмж их шаналгаатай болтол тарчилгасан болой; тиймийн тул тэрээр шатам халуунаар төөнөгдөж эхэлсэн бөлгөө.
- 4 Эдүгээ, Алма Амюлек хоёр Сайдомын нутагт байгааг тэрээр сонсоод, зүрх нь зоригжиж эхлэв; мөн тэднийг түүн дээр ирэхийг хүсэн, тэрээр даруй тэдэнд мэдээ илгээв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор тэдэнд түүний илгээсэн мэдээг даган, тэд даруйхан очив; мөн тэд гэрт нь Зиезром дээр оров; мөн тэд түүнийг орондоо өвчтэй, шатам халууран ихэд дорой байхыг нь олов; мөн түүнчлэн түүний оюун санаа алдсуудынхаа учир үлэмж шаналан байв; мөн тэрээр тэднийг хараад тэргараа сунгаж, мөн өөрийг нь эдгээхийг тэднээс гуйв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор Алма түүний гараас бариад, түүнд хэлэв: Та авралд хүргэх Христийн хүчинд итгэдэг үү
- 7 Мөн тэрээр хариулж мөн хэлсэн нь: Тийм ээ, би таны заасан бүх үгэнд итгэдэг.
- 8 Мөн Алма хэлсэн нь: Хэрэв та Христийн гэтэлгэлд итгэдэг бол та эдгээгдэж чадна.
- 9 Мөн тэр хэлсэн нь: Тийм ээ, би таны үгсийн дагуу итгэдэг.

## Alma 15

And it came to pass that Alma and Amulek were commanded to depart out of that city; and they departed, and came out even into the land of Sidom; and behold, there they found all the people who had departed out of the land of Ammonihah, who had been cast out and stoned, because they believed in the words of Alma.

And they related unto them all that had happened unto their wives and children, and also concerning themselves, and of their power of deliverance.

And also Zeezrom lay sick at Sidom, with a burning fever, which was caused by the great tribulations of his mind on account of his wickedness, for he supposed that Alma and Amulek were no more; and he supposed that they had been slain because of his iniquity. And this great sin, and his many other sins, did harrow up his mind until it did become exceedingly sore, having no deliverance; therefore he began to be scorched with a burning heat.

Now, when he heard that Alma and Amulek were in the land of Sidom, his heart began to take courage; and he sent a message immediately unto them, desiring them to come unto him.

And it came to pass that they went immediately, obeying the message which he had sent unto them; and they went in unto the house unto Zeezrom; and they found him upon his bed, sick, being very low with a burning fever; and his mind also was exceedingly sore because of his iniquities; and when he saw them he stretched forth his hand, and besought them that they would heal him.

And it came to pass that Alma said unto him, taking him by the hand: Believest thou in the power of Christ unto salvation?

And he answered and said: Yea, I believe all the words that thou hast taught.

And Alma said: If thou believest in the redemption of Christ thou canst be healed.

And he said: Yea, I believe according to thy words.

10 Мөн тэгээд Алма Их Эзэнд залбирч хэлрүүн: Ай Их Эзэн Бурхан минь, энэ хүнийг нигүүлсээч, мөн Христ дэх итгэлийнх нь дагуу түүнийг эдгээгээч гэв.

11 Мөн Алма эдгээр үгсийг хэлэхэд, Зиезром хөл дээрээ үсэрч босоод, мөн алхаж эхлэв; мөн энэ нь бүх хүмүүсийн агуу гайхашралыг төрүүлсэн аж; мөн үүний тухай мэдсэн нь бүхэл Сайдомын нутаг даяар тархав.

12 Мөн Алма Зиезромд Их Эзэнд баптисм хүртээв; мөн тэрээр тэр цагаас хойш хүмүүст номлож эхлэв.

13 Мөн Алма Сайдомын нутагт сүм байгуулан, мөн баптисм хүртэх хүсэлтэй хэнийг боловч Их Эзэний тулд баптисм хүртээх санваартнууд хийгээд багш нарыг томилон адислав.

14 Мөнхүү улиран тохиох дор тэд олон байв; учир нь тэд Сайдомын ойролцоох бүх мужуудаас цуглан ирж, мөн баптисм хүртээв.

15 Гэвч Аммонайхагийн нутагт байсан хүмүүсийн тухайд, тэд хатуу зүрх сэтгэлтэй мөн зөрүүд хүмүүс хэвээр үлдэв; мөн тэд нүглүүдээ наманчилсан нь үгүй, Алма Амюлек хоёрын бүх хүчийг чөтгөрийнх хэмээн үзэж байв; учир нь тэд Нихорын адил бодолтой байлаа, нүглүүдийнхээ наманчлалд итгэсэнгүй.

16 Мөнхүү улиран тохиох дор, Алма Амюлек хоёр нэгэнтээ түүний найзууд асан тэд мөн түүнчлэн өөрийн эцэг мөн садангуудаараа эсэргүүцэгдсэн учир, Бурханы үгийн төлөө Амюлек Аммонайхагийн нутагт байсан өөрийн бүх алт, мөн мөнгө, мөн өөрийн үнэт зүйлүүдээ орхисон ажээ;

17 Тиймийн тул, Алма Сайдомд сүм байгуулсны дараа, тэр агуу өөрчлөлтийг харжээ, тийм ээ, хүмүүс зүрх сэтгэлийнхээ бардамналын тухайд өөрчлөгдөж, мөн өөрсдийгөө Бурханы өмнө даруусгаж эхлэн, мөн тахилын ширээний өмнө Бурханыг бишрэн шүтэхээр, тэд Сатанаас, мөн үхлээс, мөн устгалаас чөлөөлөгдөж болохын тулд үргэлжлэн сэрэмжилж мөн залбирахаар өөрсдийн дугануудад өөрсдөө нэгдэн цуглаж эхэлснийг тэрээр харсын учир болой—

And then Alma cried unto the Lord, saying: O Lord our God, have mercy on this man, and heal him according to his faith which is in Christ.

And when Alma had said these words, Zeezrom leaped upon his feet, and began to walk; and this was done to the great astonishment of all the people; and the knowledge of this went forth throughout all the land of Sidom.

And Alma baptized Zeezrom unto the Lord; and he began from that time forth to preach unto the people.

And Alma established a church in the land of Sidom, and consecrated priests and teachers in the land, to baptize unto the Lord whosoever were desirous to be baptized.

And it came to pass that they were many; for they did flock in from all the region round about Sidom, and were baptized.

But as to the people that were in the land of Ammonihah, they yet remained a hard-hearted and a stiffnecked people; and they repented not of their sins, ascribing all the power of Alma and Amulek to the devil; for they were of the profession of Nehor, and did not believe in the repentance of their sins.

And it came to pass that Alma and Amulek, Amulek having forsaken all his gold, and silver, and his precious things, which were in the land of Ammonihah, for the word of God, he being rejected by those who were once his friends and also by his father and his kindred;

Therefore, after Alma having established the church at Sidom, seeing a great check, yea, seeing that the people were checked as to the pride of their hearts, and began to humble themselves before God, and began to assemble themselves together at their sanctuaries to worship God before the altar, watching and praying continually, that they might be delivered from Satan, and from death, and from destruction—

18 Эдүгээ миний хэлсэнчлэн, Алма эдгээр бүх зүйлийг үзсэн тул, тиймийн тул тэрээр Амюлекийг авч мөн Зарахемлагийн нутагт ирж, мөн түүнийг өөрийн гэрт аваачин, мөн зовлон зүдгүүрт нь түүнд тусалж, мөн түүнийг Их Эзэний талаар хүчирхэгжүүлэв.

19 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арав дахь он төгсөв.

Now as I said, Alma having seen all these things, therefore he took Amulek and came over to the land of Zarahemla, and took him to his own house, and did administer unto him in his tribulations, and strengthened him in the Lord.

And thus ended the tenth year of the reign of the judges over the people of Nephi.

## Алма 16

- 1 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арваннэг дэх онд, хоёрдугаар сарын тав дахь өдөр, Зарахемлагийн нутагт ихэд амгалан байсны дараа, бүр арваннэгдүгээр оны хоёрдугаар сарын тав дахь өдрийг хүртэл тодорхой хэдэн жилийн турш дайнууд бас тэмцлүүд үгүй байсны дараа, уг нутаг даяар дайны зар дуулдав.
- 2 Учир нь болгоогтун, леменчүүдийн их цэрэг аглаг буйдын зүгээс, нутгийн хилийг даван, бүр Аммонайхагийн хотод ирж, мөн хүмүүсийг алж мөн хотыг устгаж эхэлсэн аж.
- 3 Мөн эдүгээ улиран тохиох дор, нифайчууд тэднийг нутгаасаа туун гаргах хангалттай их цэргийг цуглуулж чадахаас өмнө тэд Аммонайха хотод байсан хүмүүсийг мөн түүнчлэн Ноагийн хилийн ойролцоох заримыг ч устгаж, мөн бусад заримыг олзлон аглаг буйд тийш авч явсан байв.
- 4 Эдүгээ улиран тохиох дор нифайчууд аглаг буйд тийш олзлогдон аваачигдсан тэднийг буцаан авахыг хүсч байв.
- 5 Тиймийн тул, нифайчуудын их цэргийг захирах ерөнхий ахмадаар томилогдсон, (мөн түүний нэр Зорам, мөн тэрээр Лихай, Эйха гэсэн хоёр хүүтэй байв)—эдүгээ Зорам мөн түүний хоёр хүү, Алма сүмийн дээрх дээд санваартан болохыг мэдсэн учир, мөн түүнд бошиглалын суу билэг байгааг дуулсан учир, тиймийн тул тэд түүнд очиж мөн тэднийг леменчүүдэд олзлогдсон өөрсдийн ах дүүсийг хайхаар аглаг буйд тийш хааш явахыг Их Эзэн хүсч байгааг түүнээс мэдэхийг хүсэв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор Алма Их Эзэнээс уг хэргийн талаар лавлав. Мөн Алма эргэж ирээд мөн тэдэнд хэлсэн нь: Болгоогтун, леменчүүд Мантай нутгийн хилийн цаадах, өмнөдийн аглаг буйд дахь хэсгээр Сидон голыг гатлах болно. Мөн болгоогтун Сидон голын зүүн эрэгт, тэнд та нар тэдэнтэй тулгарч, мөн тэнд Их Эзэн леменчүүдээр боолчлолд аваачигдсан ах дүүсийг тань та нарт чөлөөлж өгөх болно.

## Alma 16

And it came to pass in the eleventh year of the reign of the judges over the people of Nephi, on the fifth day of the second month, there having been much peace in the land of Zarahemla, there having been no wars nor contentions for a certain number of years, even until the fifth day of the second month in the eleventh year, there was a cry of war heard throughout the land.

For behold, the armies of the Lamanites had come in upon the wilderness side, into the borders of the land, even into the city of Ammonihah, and began to slay the people and destroy the city.

And now it came to pass, before the Nephites could raise a sufficient army to drive them out of the land, they had destroyed the people who were in the city of Ammonihah, and also some around the borders of Noah, and taken others captive into the wilderness.

Now it came to pass that the Nephites were desirous to obtain those who had been carried away captive into the wilderness.

Therefore, he that had been appointed chief captain over the armies of the Nephites, (and his name was Zoram, and he had two sons, Lehi and Aha)—now Zoram and his two sons, knowing that Alma was high priest over the church, and having heard that he had the spirit of prophecy, therefore they went unto him and desired of him to know whither the Lord would that they should go into the wilderness in search of their brethren, who had been taken captive by the Lamanites.

And it came to pass that Alma inquired of the Lord concerning the matter. And Alma returned and said unto them: Behold, the Lamanites will cross the river Sidon in the south wilderness, away up beyond the borders of the land of Manti. And behold there shall ye meet them, on the east of the river Sidon, and there the Lord will deliver unto thee thy brethren who have been taken captive by the Lamanites.

- 7 Мөнхүү улиран тохиох дор Зорам мөн түүний хөвгүүд, их цэрэгтэйгээ Сидон голыг гаталж, мөн Мантайн хилийн цаана Сидон голын зүүн эрэг дэх, өмнөдийн аглаг буйд тийш жагсан очив.
- 8 Мөн тэд леменчүүдийн их цэргийн дээр ирж, мөн леменчүүд тараагдаж мөн аглаг буйд тийш туугдав; мөн тэд леменчүүдээр олзлогдсон ах дүүсээ авч мөн олзлогдсон тэднээс нэг ч бодгаль алдагдсан нь үгүй. Мөн тэд өөрсдийн нутгуудыг эзэмшихээр ах дүүсээр рээ авчрагдав.
- 9 Мөн леменчүүд уг нутгаас туугдаж, мөн аммонайхагийн хүмүүс устгагдан, шүүгчдийн арван нэгдэх он тийн төгсөв; тийм ээ, Аммонайхачуудын амьд бодгаль бүхэн, мөн түүнчлэн тэдний агуу ихийнх нь учир Бурхан ч устгаж чадахгүй гэсэн агуу хот нь устгагдав.
- 10 Гэвч болгоогтун, нэг өдрийн дотор энэ нь эзгүйрч үлдэв; мөн үхдэл хүүрүүд нь ноход мөн аглаг буйдын зэрлэг араатнуудад урж тасчуулагдав.
- 11 Гэсэн хэдий ч, олон хоногийн дараа тэдний цогцос нь газрын гадаргуу дээр овоологдож, мөн тэдгээр нь өнгөцхөн хучилтаар хучигдав. Мөн эдүгээ түүний үнэр хүмүүс олон жилийн турш Аммонайхагийн нутгийг эзэмшихээр явахааргүй тийм их байв. Мөн энэ нь Нихоруудын Эзгүйрэл гэж нэрлэгдэв; учир нь алагдсан тэд Нихорын адил бодолтой байжээ; мөн тэдний нутаг эзгүйрч үлдэв.
- 12 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвандөрөв дэх он болтол леменчүүд нифайчуудын эсрэг дайтахаар дахин ирсэнгүй. Мөн Нифайн хүмүүс гурван жилийн турш бүх нутаг даяар тийн үргэлжийн амар амгаланг эдлэв.
- 13 Мөн Алма Амюлек хоёр хүмүүст өөрсдийнх нь ариун сүмүүд, мөн өөрсдийнх нь дуганууд, мөн түүнчлэн өөрсдийн нь синагогуудад иудейчүүдийн маягаар баригдсан тэдгээрт наманчлалыг номлосоор явав.
- 14 Мөн тэдний үгсийг сонсох тэр болгонд, үргэлж, ямар хүн байхаас нь эс хамааран тэдэнд Бурханы үгийг тэд түгээж байв.

And it came to pass that Zoram and his sons crossed over the river Sidon, with their armies, and marched away beyond the borders of Manti into the south wilderness, which was on the east side of the river Sidon.

And they came upon the armies of the Lamanites, and the Lamanites were scattered and driven into the wilderness; and they took their brethren who had been taken captive by the Lamanites, and there was not one soul of them had been lost that were taken captive. And they were brought by their brethren to possess their own lands.

And thus ended the eleventh year of the judges, the Lamanites having been driven out of the land, and the people of Ammonihah were destroyed; yea, every living soul of the Ammonihahites was destroyed, and also their great city, which they said God could not destroy, because of its greatness.

But behold, in one day it was left desolate; and the carcasses were mangled by dogs and wild beasts of the wilderness.

Nevertheless, after many days their dead bodies were heaped up upon the face of the earth, and they were covered with a shallow covering. And now so great was the scent thereof that the people did not go in to possess the land of Ammonihah for many years. And it was called Desolation of Nehors; for they were of the profession of Nehor, who were slain; and their lands remained desolate.

And the Lamanites did not come again to war against the Nephites until the fourteenth year of the reign of the judges over the people of Nephi. And thus for three years did the people of Nephi have continual peace in all the land.

And Alma and Amulek went forth preaching repentance to the people in their temples, and in their sanctuaries, and also in their synagogues, which were built after the manner of the Jews.

And as many as would hear their words, unto them they did impart the word of God, without any respect of persons, continually.

15 Мөн тийн Алма Амюлек хоёр, мөн түүнчлэн уг ажилд сонгогдсон өөр олон нь, бүх нутаг даяар үгийг номлохоор явав. Мөн сүмийн байгуулалт уг нутаг даяар эргэн тойрны газар болгонд нифайчуудын бүх хүмүүсийн дунд өргөн тархсан байлаа.

16 Мөн тэдний дунд тэгш бус байдал байсангүй; түүний ирэлтийн үед тэдний дунд заагдах үгийг хүлээн авахад хүмүүний үрсийн оюуныг бэлтгэхээр, өөрөөр хэлбэл тэдний зүрх сэтгэлийг бэлтгэхээр Их Эзэн өөрийн Сүнснийг уг нутгийн бүх гадаргуу дээр юүлсэн болой—

17 Тэд үгийн эсрэг хатуурхахгүй байж болохын тулд, тэд итгэлгүйгээр үл байж, мөн устгал тийш одохгүй байж болохын тулд, харин тэд үгийг баяртайгаар хүлээн авч, мөн мөчир адил үнэн ороонгод залгагдаж болохын тулд, тэд Их Эзэн Бурханыхаа амралтад орж болохын тулд болой.

18 Эдүгээ хүмүүсийн дунд одсон санваартнууд бүх худал, мөн заль мэхүүд, мөн атаа жөгөө, мөн маргаан мэтгэлцээн, мөн өс хонзон, мөн доромжлолууд, мөн хулгай, дээрэм, тонуул, аллага, садар самууныг үйлдэх хийгээд бүхэл төрлийн шунаг тачаангуй байдлын эсрэг, эдгээр зүйл ийм байх ёсгүй хэмээн хашгиран номлов—

19 Удахгүй ирэх ёстой тэр зүйлийг номлож, тийм ээ, Бурханы Хүүгийн ирэлтийг, түүний зүдгүүрүүд хийгээд үхлийг мөн түүнчлэн нас барагсдын амилуулалтыг номлов.

20 Мөн хүмүүсийн олон нь Бурханы Хүүгийн ирэх ёстой тэр газар нь хаана болохыг лавлав; мөн тэрээр өөрийн амилалтын дараа тэдэн дээр хүрч ирэх болно хэмээн тэд заалгасан ажгуу; мөн үүнийг хүмүүс агуу их баясал мөн баяртайгаар сонссон болой.

21 Мөн эдүгээ уг сүм нутаг даяар байгуулагдсаны дараа—чөтгөрийг ялах ялалтыг үзсэн байв, мөн Бурханы үг цэвэр ариун байдлаараа бүх нутагт номлогдож, мөн Их Эзэн адислалуудаа хүмүүсийн дээр юүлсээр байв—Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвандөрөв дэх он тийн төгсөв.

And thus did Alma and Amulek go forth, and also many more who had been chosen for the work, to preach the word throughout all the land. And the establishment of the church became general throughout the land, in all the region round about, among all the people of the Nephites.

And there was no inequality among them; the Lord did pour out his Spirit on all the face of the land to prepare the minds of the children of men, or to prepare their hearts to receive the word which should be taught among them at the time of his coming—

That they might not be hardened against the word, that they might not be unbelieving, and go on to destruction, but that they might receive the word with joy, and as a branch be grafted into the true vine, that they might enter into the rest of the Lord their God.

Now those priests who did go forth among the people did preach against all lyings, and deceivings, and envyings, and strifes, and malice, and revilings, and stealing, robbing, plundering, murdering, committing adultery, and all manner of lasciviousness, crying that these things ought not so to be—

Holding forth things which must shortly come; yea, holding forth the coming of the Son of God, his sufferings and death, and also the resurrection of the dead.

And many of the people did inquire concerning the place where the Son of God should come; and they were taught that he would appear unto them after his resurrection; and this the people did hear with great joy and gladness.

And now after the church had been established throughout all the land—having got the victory over the devil, and the word of God being preached in its purity in all the land, and the Lord pouring out his blessings upon the people—thus ended the fourteenth year of the reign of the judges over the people of Nephi.



*Бурханы үгийн төлөө хаант улсыг захирах эрхээсээ татгалзаж, мөн леменчүүдэд номлохоор Нифайн нутаг өвд одсон Мозаягийн хөвгүүдийн шастир; тэдний зүдгүүрүүд мөн чөлөөлөлт—Алмагийн цэдгийн дагуу оривой.*

## Алма 17

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма Гидеоны нутгаас урагш Мантайн нутгийн зүг аялж байх зуураа, болгоогтун, түүний гайхашралыг төрүүлсэн нь, тэрээр Зарахемлагийн нутгийн зүг аялан яваа Мозаягийн хөвгүүдтэй дайралдав.
- 2 Эдүгээ тэнгэр элч түүнд анх үзэгдсэн тэр цагт Мозаягийн энэ хөвгүүд Алматай хамт байжээ; тиймийн тул Алма ах дүүсээ хараад үлэмж баярлав; мөн түүний баяр хөөрийг илүүгээр нэмсэн нь, тэд Их Эзэний хувьд түүний ах дүүс хэвээрээ байсны учир болой; тийм ээ, мөн тэд үнэний мэдлэгт хүчтэй болсон байв; учир нь тэд зөв ойлголттой хүмүүс мөн тэд Бурханы үгийг мэдэж болохын тулд судруудыг хичээнгүйлэн судалсан байв.
- 3 Гэвч энэ нь бүгд бус; тэд өөрсдийгөө их залбирал, мөн мацаг барилганд зориулсан байв; тиймийн тул тэдэнд бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг байлаа, мөн тэд зааж байхдаа Бурханаас хүлээн авсан хүч мөн эрх мэдэлтэйгээр тэд зааж байв.
- 4 Мөн тэд леменчүүдийн дунд арван дөрвөн жилийн турш Бурханы үгийг зааж, олныг үнэний мэдлэгт авчрахдаа их амжилттай байв; тийм ээ, тэдний үгсийн хүчээр Бурханы тахилын ширээний өмнө, түүний нэрийг дуудаж мөн түүний өмнө нүглүүдээ хүлээхээр олон нь авчрагдсан бөлгөө.
- 5 Эдүгээ тэдний аяллын үед тэдэнд тохиолдсон нөхцөл нь эдгээр болой, учир нь, тэдэнд олон зүдрэл байв; тэд өлсөж, цанган мөн ядрах мэтээр биеэрээ ч мөн оюунаараа ч аль алинаар нь ихэд зовж, мөн түүнчлэн сүнсээрээ ихэд хөдөлмөрлөв.
- 6 Эдүгээ эдгээр нь тэдний аянууд байв: Шүүгчдийн эхний жилд, өөрсдийн эцэг, Мозаятай, тэд салах ёс гүйцэтгэсний дараа; эцэг нь тэдний дээр шилжүүлэхийг хүссэн хаант улсаас татгалзсаны дараа, мөн түүнчлэн энэ нь хүмүүсийн бодол байв;

*An account of the sons of Mosiah, who rejected their rights to the kingdom for the word of God, and went up to the land of Nephi to preach to the Lamanites; their sufferings and deliverance—according to the record of Alma.*

## Alma 17

And now it came to pass that as Alma was journeying from the land of Gideon southward, away to the land of Manti, behold, to his astonishment, he met with the sons of Mosiah journeying towards the land of Zarahemla.

Now these sons of Mosiah were with Alma at the time the angel first appeared unto him; therefore Alma did rejoice exceedingly to see his brethren; and what added more to his joy, they were still his brethren in the Lord; yea, and they had waxed strong in the knowledge of the truth; for they were men of a sound understanding and they had searched the scriptures diligently, that they might know the word of God.

But this is not all; they had given themselves to much prayer, and fasting; therefore they had the spirit of prophecy, and the spirit of revelation, and when they taught, they taught with power and authority of God.

And they had been teaching the word of God for the space of fourteen years among the Lamanites, having had much success in bringing many to the knowledge of the truth; yea, by the power of their words many were brought before the altar of God, to call on his name and confess their sins before him.

Now these are the circumstances which attended them in their journeyings, for they had many afflictions; they did suffer much, both in body and in mind, such as hunger, thirst and fatigue, and also much labor in the spirit.

Now these were their journeyings: Having taken leave of their father, Mosiah, in the first year of the judges; having refused the kingdom which their father was desirous to confer upon them, and also this was the minds of the people;

- 7 Гэсэн хэдий ч тэд Зарахемлагийн нутгаас одож, мөн өөрсдийн илд, мөн өөрсдийн жад, мөн өөрсдийн нум, мөн өөрсдийн сум, мөн өөрсдийн дүүгүүрүүдийг авчээ; мөн аглаг буйдад байх зуураа өөрсөддөө хүнс залгуулж болохын тулд тэд үүнийг хийсэн болой.
- 8 Мөн тийн тэд өөрсдийн сонгосон хэдтэйгээ Нифайн нутаг өөд явж, Бурханы үгийг леменчүүдэд номлохоор аглаг буйд тийш одов.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд аглаг буйдад олон хоног аялж, мөн хэрэв энэ нь боломжтой аваас өөрсдийн ах дүүс, леменчүүдийг үнэний мэдлэгт, зөв бус байсан тэр эцэг өвгөдийнх нь уламжлалуудын дорд байдлын тухай мэдлэгт авчрахад Бурханы мутарт зэмсэг болж болохын тулд, тэдэнтэй хамт явж, мөн тэдэнтэй оршин байх өөрийн Сүнсний хэсгийг Их Эзэн тэдэнд соёрхоосой хэмээн тэд ихэд мацаг барьж мөн ихэд залбирав.
- 10 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн өөрийн Сүнсээр тэдэнд зочилж, мөн тэдэнд: Тайтгарагтун хэмээв. Мөн тэд тайтгарцгаав.
- 11 Мөн Их Эзэн тэдэнд түүнчлэн хэлсэн нь: Өөрсдийн ах дүүс леменчүүдийн дунд явж, мөн мийн үгийг тогтоо; хэдий тийм ч та нар зовлонгууд мөн зүдрэлүүддээ тэвчээртэй байх болно, та нар надаар дамжуулж сайн үлгэр жишээг тэдэнд үзүүлж болохын тул болой, мөн олон бодгалийн авралын төлөө би та нарыг өөрийн мутар дахь зэмсэг болгох болно.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Мозаягийн хөвгүүдийн, мөн түүнчлэн тэдэнтэй байсан тэдний зүрх сэтгэл ч бас, Бурханы үгийг тэдэнд тунхаглахаар леменчүүдэд очих зоригийг олов.
- 13 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн нутгийн хилд хүрч ирээд, тэд өөрсдөө хуваагдаж мөн тэд ургацаа хураасны эцэст дахин уулзах болно хэмээн Их Эзэнд итгэн нэг нэгнээсээ салцгаав; учир нь тэдний хүлээсэн ажил агууг ухаарсан ажгуу.

Nevertheless they departed out of the land of Zarahemla, and took their swords, and their spears, and their bows, and their arrows, and their slings; and this they did that they might provide food for themselves while in the wilderness.

And thus they departed into the wilderness with their numbers which they had selected, to go up to the land of Nephi, to preach the word of God unto the Lamanites.

And it came to pass that they journeyed many days in the wilderness, and they fasted much and prayed much that the Lord would grant unto them a portion of his Spirit to go with them, and abide with them, that they might be an instrument in the hands of God to bring, if it were possible, their brethren, the Lamanites, to the knowledge of the truth, to the knowledge of the baseness of the traditions of their fathers, which were not correct.

And it came to pass that the Lord did visit them with his Spirit, and said unto them: Be comforted. And they were comforted.

And the Lord said unto them also: Go forth among the Lamanites, thy brethren, and establish my word; yet ye shall be patient in long-suffering and afflictions, that ye may show forth good examples unto them in me, and I will make an instrument of thee in my hands unto the salvation of many souls.

And it came to pass that the hearts of the sons of Mosiah, and also those who were with them, took courage to go forth unto the Lamanites to declare unto them the word of God.

And it came to pass when they had arrived in the borders of the land of the Lamanites, that they separated themselves and departed one from another, trusting in the Lord that they should meet again at the close of their harvest; for they supposed that great was the work which they had undertaken.

14 Мөн энэ нь лавтайяа агуу их зүйл байв, учир нь тэд Бурханы үгийг зэрлэг мөн хатуу сэтгэлт мөн харгис хүмүүст; нифайчуудыг хөнөөхдөө, мөн тэднийг дээрэмдэж мөн тонохдоо баясдаг хүмүүст номлох үүргийг хүлээн авчээ; мөн тэдний зүрх сэтгэл баялгууд, өөрөөр хэлбэл алт мөн мөнгөн дээр мөн үнэт чулуунууд дээр байрласан байлаа; хэдий тийм ч тэд өөрсдийнхөө төлөө өөрсдийн гараар хөдөлмөрлөхгүй байж болохын тулд тэд эдгээр зүйлийг аллагаар мөн тонуулаар олж авахыг эрэлхийлдэг байв.

15 Наманчлалын нөхцөл дор Их Эзэний амлалтууд тэдэнд боломжтой болсон хэдий ч тэд тийн маш залхаг хүмүүс байв, олон нь хиймэл шүтээнүүдийг биширч, мөн тэдний эцэг өвгөдийн уламжлалуудын учир Бурханы зүхэл тэдний дээр буусан ажээ.

16 Тиймийн тул, энэ нь тэднийг наманчлалд авчирч магад хэмээн, Мозаягийн хөвгүүд уг ажлыг хийхээр хүлээсний шалтгаан байв; тэд гэтэлгэлийн төлөвлөгөөний талаар тэдэнд мэдүүлж болох магад хэмээсний учир бөлгөө.

17 Тиймийн тул тэд өөрсдөө нэг нэгнээсээ салцгааж, мөн хүн бүр ганцаараа түүнд өгөгдсөн Бурханы үг болон хүчний дагуу тэдний дунд одов.

18 Эдүгээ Аммон тэдний дунд ахлагч нь байв, өөрөөр хэлбэл тэдэнд зааварладаг байжээ, мөн тэрээр тэдний хэд хэдэн албан тушаалынх нь дагуу тэднийг адисалсны дараа, Бурханы үгийг тэдэнд хэлснийхээ дараа, өөрөөр хэлбэл явахынхаа өмнө тэдэнд зааварласныхаа дараа тэднээс салж одов; мөн тийн тэд уг нутаг даяар тус тусын аяныг хөөв.

19 Мөн Аммон, түүнчлэн леменчүүд болсон Ишмэилийн хөвгүүдийн нэрээр нэрлэгдсэн нутаг болох Ишмэилийн нутагт очив.

20 Мөн Аммон Ишмэилийн нутагт ормогц, түүнийг, тэдний гарт орсон нифайчуудыг хүлж, мөн хааны өмнө тэднийг аваачдаг заншлаараа леменчүүд түүнийг баривчилж мөн түүнийг хүлэв; мөн тийн тэднийг алах, эсвээс тэднийг боолчлолд байлгах, эсвээс тэднийг шоронд хорих, эсвээс тэднийг нутгаасаа гарган хаях нь хааны таалалд, түүний хүсэл мөн тааллын дагуу үлддэг байв.

And assuredly it was great, for they had undertaken to preach the word of God to a wild and a hardened and a ferocious people; a people who delighted in murdering the Nephites, and robbing and plundering them; and their hearts were set upon riches, or upon gold and silver, and precious stones; yet they sought to obtain these things by murdering and plundering, that they might not labor for them with their own hands.

Thus they were a very indolent people, many of whom did worship idols, and the curse of God had fallen upon them because of the traditions of their fathers; notwithstanding the promises of the Lord were extended unto them on the conditions of repentance.

Therefore, this was the cause for which the sons of Mosiah had undertaken the work, that perhaps they might bring them unto repentance; that perhaps they might bring them to know of the plan of redemption.

Therefore they separated themselves one from another, and went forth among them, every man alone, according to the word and power of God which was given unto him.

Now Ammon being the chief among them, or rather he did administer unto them, and he departed from them, after having blessed them according to their several stations, having imparted the word of God unto them, or administered unto them before his departure; and thus they took their several journeys throughout the land.

And Ammon went to the land of Ishmael, the land being called after the sons of Ishmael, who also became Lamanites.

And as Ammon entered the land of Ishmael, the Lamanites took him and bound him, as was their custom to bind all the Nephites who fell into their hands, and carry them before the king; and thus it was left to the pleasure of the king to slay them, or to retain them in captivity, or to cast them into prison, or to cast them out of his land, according to his will and pleasure.

21 Мөн тийн Аммон Ишмэилийн нутгийг захирсан хааны өмнө хүргэгдэв; мөн түүний нэр Лемонай байв; мөн тэрээр Ишмэилийн удмынх байжээ.

22 Мөн хаан Аммоноос тэрээр уг нутагт леменчүүдийн дунд, өөрөөр хэлбэл түүний хүмүүсийн дунд орших хүсэлтэй эсэхийг лавласан ажгуу.

23 Мөн Аммон түүнд хэлэв: Тийм ээ, би хэсэг хугацаанд; магадгүй үхэх өдрөө хүртэл энэ хүмүүсийн дунд орших хүсэлтэй хэмээв.

24 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хаан Аммоныг таалан үзэж, мөн түүний хүлээсийг тайлах болгов; мөн тэрээр Аммон өөрийнх нь охидоос нэгийг нь эхнэр болгон аваасай хэмээн хүсэв.

25 Харин Аммон түүнд хэлэв: Үгүй, харин би таны зарц байх болно. Тиймийн тул Аммон, Лемонай хааны зарц болов. Мөнхүү улиран тохиох дор тэрээр леменчүүдийн заншлын дагуу Лемонайн сүргийг хариулахаар бусад зарим зарц нарын дунд байрлуулав.

26 Мөн тэрээр хааны үйлчлэлд гурав хоног байсны дараа, тэрээр лемен үндэсний зарц нартай хамт сүргийг авч Себасын ус гэж нэрлэгдсэн устай газарт очиход нь, мөн бүх леменчүүд тэдгээр нь ус ууж болно хэмээн сүргээ тийш туун очжээ—

27 Тиймийн тул, Аммон болон хааны зарц нар сүргээ энэ устай газрын зүг тууж явтал, болгоогтун, маалаа усалж байсан тодорхой тооны леменчүүд босож мөн Аммоны болон хааны зарц нарын сүргийг тарааж, мөн тэдгээр нь тал тал тийш зугтах хүртэл нь тэдгээрийг тараав.

28 Эдүгээ хааны зарц нар бувтналдаж эхлэв, хэлсэн нь: Эдүгээ сүрэг нь эдгээр эрчүүдээр ёс бусаар тараагдсан учир бидний ах дүүсийг тэгсэн шигээ, хаан биднийг алах болно. Мөн тэд үлэмж ихээр уйлж эхлэн, өгүүлсэн нь: Болгоогтун, бидний сүрэг аль хэдийн тараагдсан.

And thus Ammon was carried before the king who was over the land of Ishmael; and his name was Lamoni; and he was a descendant of Ishmael.

And the king inquired of Ammon if it were his desire to dwell in the land among the Lamanites, or among his people.

And Ammon said unto him: Yea, I desire to dwell among this people for a time; yea, and perhaps until the day I die.

And it came to pass that king Lamoni was much pleased with Ammon, and caused that his bands should be loosed; and he would that Ammon should take one of his daughters to wife.

But Ammon said unto him: Nay, but I will be thy servant. Therefore Ammon became a servant to king Lamoni. And it came to pass that he was set among other servants to watch the flocks of Lamoni, according to the custom of the Lamanites.

And after he had been in the service of the king three days, as he was with the Lamanitish servants going forth with their flocks to the place of water, which was called the water of Sebus, and all the Lamanites drive their flocks hither, that they may have water—

Therefore, as Ammon and the servants of the king were driving forth their flocks to this place of water, behold, a certain number of the Lamanites, who had been with their flocks to water, stood and scattered the flocks of Ammon and the servants of the king, and they scattered them insomuch that they fled many ways.

Now the servants of the king began to murmur, saying: Now the king will slay us, as he has our brethren because their flocks were scattered by the wickedness of these men. And they began to weep exceedingly, saying: Behold, our flocks are scattered already.

29 Эдүгээ тэд алагдахаас айсны учир уйлжээ. Эдүгээ Аммон үүнийг хараад дотроо зүрх сэтгэл нь баяраар бялхав; учир нь, тэр хэлэв, энэ сүргийг хаанд эргүүлэн өгснөөр би өөрийн хүчийг, өөрөөр хэлбэл надад буй тэр хүчийг, эдгээр бусад зарц нарт үзүүлэх болно, би эдгээр бусад зарц нарын сэтгэлийг татаж болохын тулд, тэднийг үгсэд минь итгэхэд би удирдаж болохын тулд буюу.

30 Мөн эдүгээ, тэрээр өөрийн ах дүүс гэж нэрлэсэн тэдний зовлонг хараад бодсон Аммоны бодол нь эдгээр байв.

31 Мөнхүү улиран тохиох дор тэрээр өөрийн үгсээр тэднийг зоригжуулж, хэлсэн нь: Ах дүүс минь, урамтай байцгаа мөн сүргийг эрэхээр явцгаа, мөн бид тэдгээрийг цуглуулж бас тэдгээрийг устай газар буцаан авчрах болно; мөн тийн бид хаанд сүргийг нь хадгалан хамгаалж тэгснээр тэр биднийг алахгүй байх болно.

32 Мөнхүү улиран тохиох дор тэд сүргийг хайн явж, мөн тэд Аммоныг даган, мөн тэд их хурднаар яаран явж мөн хааны сүргийг тогтоож, мөн тэдгээрийг дахин устай газар нэгтгэн цуглуулав.

33 Мөн сайхь эрчүүд тэдний сүргийг тараахаар дахин босож ирэв; гэвч Аммон ах дүүстээ хэлсэн нь: Зугтаалгахгүйн тул сүргийг тойрон хүрээл; мөн би явж мөн бидний сүргийг тараасан эдгээр эрчүүдтэй тэмцэлдье.

34 Тиймийн тул, тэд Аммон өөрсдөд нь зарлигласныг хийж, мөн тэрээр урагш одож мөн Себасын усны дэргэд зогсоцгоож байсан тэдэнтэй тэмцэлдэхээр зогсов; мөн тэд тоогоороо цөөн байсангүй.

35 Тиймийн тул тэд Аммонаас айсангүй, учир нь эрчүүдийн нэг нь тэдний хүслийн дагуу түүнийг алж чадна хэмээн тэд боджээ, учир нь тэрээр хөвгүүдийг нь тэдний гараас чөлөөлнө хэмээн Их Эзэн Мозаяд амласныг тэд мэдсэнгүй; бас Их Эзэний талаар юу ч эс мэдэх ажээ; тиймийн тул тэд ах дүүсийнхээ устгалд баясдаг байв; мөн үүнийхээ улмаас тэд хааны сүргийг тараахаар босоцгоосон аж.

Now they wept because of the fear of being slain. Now when Ammon saw this his heart was swollen within him with joy; for, said he, I will show forth my power unto these my fellow-servants, or the power which is in me, in restoring these flocks unto the king, that I may win the hearts of these my fellow-servants, that I may lead them to believe in my words.

And now, these were the thoughts of Ammon, when he saw the afflictions of those whom he termed to be his brethren.

And it came to pass that he flattered them by his words, saying: My brethren, be of good cheer and let us go in search of the flocks, and we will gather them together and bring them back unto the place of water; and thus we will preserve the flocks unto the king and he will not slay us.

And it came to pass that they went in search of the flocks, and they did follow Ammon, and they rushed forth with much swiftness and did head the flocks of the king, and did gather them together again to the place of water.

And those men again stood to scatter their flocks; but Ammon said unto his brethren: Encircle the flocks round about that they flee not; and I go and contend with these men who do scatter our flocks.

Therefore, they did as Ammon commanded them, and he went forth and stood to contend with those who stood by the waters of Sebus; and they were in number not a few.

Therefore they did not fear Ammon, for they supposed that one of their men could slay him according to their pleasure, for they knew not that the Lord had promised Mosiah that he would deliver his sons out of their hands; neither did they know anything concerning the Lord; therefore they delighted in the destruction of their brethren; and for this cause they stood to scatter the flocks of the king.

36 Гэвч Аммон босож мөн дүүгүүрээрээ тэдэн рүү чулуу нүүлгэж эхлэв; тийм ээ, их хүчтэйгээр чулууг тэдний дунд тэр дүүгүүрдэж байв; мөн тийн тэрээр тэдний хэд хэдийг алсан учир, үүний хэрээр тэд түүний хүчийг гайхан бахдаж эхлэв; гэсэн хэдий ч тэд ах дүүс нь алуулсан учир ууртай байв, мөн тэд түүнийг унах ёстой хэмээн хатуу шийдсэн байв; тиймийн тул, тэд түүнийг чулуугаар онож чадахгүй байгаагаар хараад, бороохой шийдэмтэйгээр түүнийг алахаар тэд давшин ирэв.

37 Гэвч болгоогтун, Аммоныг цохихоор шийдмээ өргөсөн хүн бүрийг, тэрээр илдээрээ гарыг нь тас цавчив; тодруулбал тэр илднийхээ ирээр тэдний гарыг цавчин тэдний дайралтуудыг эсэргүүцэж, үүний хэрээр тэд гайхан цочирдож эхлэв, мөн түүнээс зугтаж эхлэв; тийм ээ, мөн тэд цөөн тоотой байсангүй; мөн тэрээр гарынхаа хүчээр тэднийг зугтахад хүргэв.

38 Эдүгээ тэдний зургаа нь дүүгүүрт унасан байлаа, харин тэр тэдний удирдагчаас нь өөр хэнийг ч илдээрээ алсан нь үгүй; мөн тэр түүний эсрэг далайсан тэр болгоны гарыг тас цавчсан аж, мөн тэд цөөн байгаагүй билээ.

39 Мөн тэрээр тэднийг хол хөөгөөд, тэр эргэж ирэв, мөн тэд сүргээ усалж мөн тэдгээрийг хааны бэлчээрт эргүүлж аваачаад, тэгээд хаанд очиж, түүнийг хөнөөхийг эрэлхийлсэн тэдний, Аммоны илдээр тас цавчигдсан, гаруудыг үзүүлэв; мөн тэдний хийсэн зүйлүүдийн гэрч болгон хаанд тэдгээр нь авчрагдав.

But Ammon stood forth and began to cast stones at them with his sling; yea, with mighty power he did sling stones amongst them; and thus he slew a certain number of them insomuch that they began to be astonished at his power; nevertheless they were angry because of the slain of their brethren, and they were determined that he should fall; therefore, seeing that they could not hit him with their stones, they came forth with clubs to slay him.

But behold, every man that lifted his club to smite Ammon, he smote off their arms with his sword; for he did withstand their blows by smiting their arms with the edge of his sword, insomuch that they began to be astonished, and began to flee before him; yea, and they were not few in number; and he caused them to flee by the strength of his arm.

Now six of them had fallen by the sling, but he slew none save it were their leader with his sword; and he smote off as many of their arms as were lifted against him, and they were not a few.

And when he had driven them afar off, he returned and they watered their flocks and returned them to the pasture of the king, and then went in unto the king, bearing the arms which had been smitten off by the sword of Ammon, of those who sought to slay him; and they were carried in unto the king for a testimony of the things which they had done.

## Алма 18

- 1 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хаан өөрийн зарц нарыг урагшилж, уг хэргийн талаар харсан бүх зүйлийг гэрчлэх болгов.
- 2 Мөн тэд бүгд өөрсдийн харсан зүйлийг гэрчлээд, мөн тэрээр Аммон түүний сүргийг хадгалан хамгаалахад итгэлтэйг нь, мөн түүнчлэн түүнийг алахаар эрэлхийлсэн тэдний эсрэг тэмцэлдэхэд түүний агуу хүчийг мэдсэний дараа, тэрээр үлэмж гайхан балмагдаж, мөн хэлэв: Энэ бол хүнээс нэт нь гарцаагүй юм. Болгоогтун, тэдний аллагуудын учир агуу шийтгэлүүдийг энэ хүмүүсийн дээр илгээдэг Агуу Их Сүнс нь энэ бус уу
- 3 Мөн тэд хаанд хариулж, мөн хэлэв: Тэрээр Агуу Их Сүнс үү эсвэл хүн үү гэдгийг бид мэдэхгүй; харин бидний мэдэх нь, тэр хааны дайснуудад алагдахгүй; бас тэр бидэнтэй байхад хааны сүргийг тэд тарааж чадахгүй, түүний чадвар болоод агуу хүчний учир буюу; тиймийн тул, тэр бол хааны анд гэдгийг бид мэднэ. Мөн эдүгээ, Ай хаантан, хүнд тийм агуу хүч байдагт бид итгэдэггүй, учир нь тэр алагдахгүйг бид мэднэ.
- 4 Мөн эдүгээ, хаан эдгээр үгийг дуулаад, тэрээр тэдэнд хэлэв: Эдүгээ энэ бол Агуу Их Сүнс мөн гэдгийг би мэдлээ; мөн энэ үед би та нарыг ах дүүсийн чинь адил алахгүй байж болохын тулд та нарын амийг хамгаалахаар тэрээр бууж иржээ. Эдүгээ энэ нь бидний эцэг өвгөдийн ярьсан Агуу Их Сүнс болой.
- 5 Эдүгээ Агуу Их Сүнс байдаг гэдэг нь эцгээсээ хүлээн авсан Лемонайн уламжлал байв. Агуу Их Сүнсэнд тэд итгэсэн хэдий ч, тэд ямар ч юм хийсэн тэдний зөв хэмээн бодсон ажээ; гэсэн хэдий ч, Лемонай, зарц нараа алахдаа бурууг үйлдсэн болов уу хэмээх айдсаар үлэмж ихээр айж эхлэв;
- 6 Учир нь тэдний ах дүүс устай газар тэдний сүргүүдийг тараасан учир тэрээр тэднээс олныг алсан байв; мөн тийн, тэд сүргээ тараалгасан учир тэд алагджээ.

## Alma 18

And it came to pass that king Lamoni caused that his servants should stand forth and testify to all the things which they had seen concerning the matter.

And when they had all testified to the things which they had seen, and he had learned of the faithfulness of Ammon in preserving his flocks, and also of his great power in contending against those who sought to slay him, he was astonished exceedingly, and said: Surely, this is more than a man. Behold, is not this the Great Spirit who doth send such great punishments upon this people, because of their murders?

And they answered the king, and said: Whether he be the Great Spirit or a man, we know not; but this much we do know, that he cannot be slain by the enemies of the king; neither can they scatter the king's flocks when he is with us, because of his expertness and great strength; therefore, we know that he is a friend to the king. And now, O king, we do not believe that a man has such great power, for we know he cannot be slain.

And now, when the king heard these words, he said unto them: Now I know that it is the Great Spirit; and he has come down at this time to preserve your lives, that I might not slay you as I did your brethren. Now this is the Great Spirit of whom our fathers have spoken.

Now this was the tradition of Lamoni, which he had received from his father, that there was a Great Spirit. Notwithstanding they believed in a Great Spirit, they supposed that whatsoever they did was right; nevertheless, Lamoni began to fear exceedingly, with fear lest he had done wrong in slaying his servants;

For he had slain many of them because their brethren had scattered their flocks at the place of water; and thus, because they had had their flocks scattered they were slain.

- 7 Эдүгээ Себасын усны дэргэд хүмүүсийн сүргийг тараахаар, тэгснээрээ тэд тараагдсанаас олныг нь нутагтаа тууж болохын тулд зогсдог нь эдгээр леменчүүдийн зуршил байв, учир нь тэдний дунд ингэж тонуул хийх нь зуршил болсон байлаа.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хаан зарц нараасаа лавлаж, өгүүлсэн нь: Тийм агуу хүчтэй тэр хүн хаана байна
- 9 Мөн тэд түүнд хэлэв: Болгоогтун, тэр таны морьдыг тэжээж байна. Эдүгээ хаан зарц нартаа сүргийг нь услахаас урьд тэд морьдыг нь мөн сүйх тэрэгнүүдийг нь бэлтгэж мөн Нифайн нутагт хүргэж өгөхийг зарлигласан байв; учир нь бүх нутгийг захирах хаан болох Лемонайн эцгээр, Нифайн нутагт их хурим болох нь товлогдсон ажээ.
- 10 Эдүгээ Аммон түүний морьд мөн түүний сүйх тэргүүдийг бэлтгэж буйг хаан Лемонай сонсоод, Аммоны итгэлтэйн учир тэр илүүтэй ихээр гайхан балмагдсан байж, хэлрүүн: Энэ хүний адил ийм итгэлтэй зарц миний бүх зарц нарын дунд байгаагүй нь гарцаагүй; тодруулбал тэрээр бүр миний бүх зарлигуудыг, тэдгээрийг гүйцэлдүүлэхээ санадаг.
- 11 Эдүгээ энэ бол Агуу Их Сүнс гэдгийг би гарцаагүй мэдлээ, мөн би түүнийг над дээр ирэхийг хүсэхсэн, гэвч би зүрхлэхгүй байна.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Аммон морьдыг мөн сүйх тэргүүдийг хаанд мөн түүний зарц нарт бэлэн болгоод, тэрээр хаанд очиж, мөн тэрээр хааны царай төрх өөрчлөгдсөнийг харав; тиймийн тул тэрээр түүний дэргэдээс холдон буцахыг завдав.
- 13 Мөн хааны зарц нарын нэг нь түүнд Раббана хэмээж, тэр нь хөрвүүлбээс хүчит эсвээс агуу их хаан гэсэн утгатай, учир нь тэд өөрсдийн хаадыг хүчит хэмээн үздэг байв; мөн тэрээр түүнд тийн хэлэв: Раббана, хаан таныг үлдэхийг хүснэ.
- 14 Тиймийн тул Аммон хааны зүг эргэж мөн түүнд хэлэв: Ай хаантан, та намайг таны төлөө юу хийхийг хүснэв? Мөн тэдний цагийн хэмжүүрийн дагуу нэг цагийн турш хаан түүнд хариулсангүй, учир нь тэр түүнд юу хэлэх ёстойгоо мэдсэнгүй.
- 15 Мөнхүү улиран тохиох дор Аммон түүнд дахин хэлэв: Та надаас юу хүснэв? Гэвч хаан түүнд хариулсангүй.

Now it was the practice of these Lamanites to stand by the waters of Sebus to scatter the flocks of the people, that thereby they might drive away many that were scattered unto their own land, it being a practice of plunder among them.

And it came to pass that king Lamoni inquired of his servants, saying: Where is this man that has such great power?

And they said unto him: Behold, he is feeding thy horses. Now the king had commanded his servants, previous to the time of the watering of their flocks, that they should prepare his horses and chariots, and conduct him forth to the land of Nephi; for there had been a great feast appointed at the land of Nephi, by the father of Lamoni, who was king over all the land.

Now when king Lamoni heard that Ammon was preparing his horses and his chariots he was more astonished, because of the faithfulness of Ammon, saying: Surely there has not been any servant among all my servants that has been so faithful as this man; for even he doth remember all my commandments to execute them.

Now I surely know that this is the Great Spirit, and I would desire him that he come in unto me, but I durst not.

And it came to pass that when Ammon had made ready the horses and the chariots for the king and his servants, he went in unto the king, and he saw that the countenance of the king was changed; therefore he was about to return out of his presence.

And one of the king's servants said unto him, Rabbanah, which is, being interpreted, powerful or great king, considering their kings to be powerful; and thus he said unto him: Rabbanah, the king desireth thee to stay.

Therefore Ammon turned himself unto the king, and said unto him: What wilt thou that I should do for thee, O king? And the king answered him not for the space of an hour, according to their time, for he knew not what he should say unto him.

And it came to pass that Ammon said unto him again: What desirest thou of me? But the king answered him not.



16 Мөнхүү улиран тохиох дор Аммон, Бурханы Сүнсээр дүүргэгдсэн учир, тиймийн тул тэр хааны бодлуудыг мэдэрсэн болой. Мөн тэрээр түүнд хэлэв: Та намайг таны зарц нар болон таны сүргийг хамгаалсан, таны мал мөн таны зарц нарыг хамгаалахын тул, тэдний ах дүүсийн долоог нь дүүгүүр болон илдээр алж, мөн бусдынх нь гарыг тас цохьсоныг дуулсны учир буюу; болгоогтун, таны гайхлыг төрүүлсэн нь энэ үү

17 Би танд хэлнэ, юу нь таны гайхлыг ийм ихээр төрүүлсэн билээ? Болгоогтун, би бол хүн, мөн таны зарц билээ; тиймийн тул, таны хүссэн зөв юуг боловч, би түүнийг хийх болно.

18 Эдүгээ хаан энэ үгсийг дуулаад, тэрээр дахин гайхав, учир нь Аммон түүний бодлуудыг мэдэж чадсаныг болгоов; гэвч энэ нь болсон хэдий ч Лемонай хаан амаа нээж, мөн түүнд хэлэв: Та хэн билээ? Та бүх зүйлийг мэддэг Агуу Их Сүнс мөн үү

19 Аммон хариулж мөн түүнд хэлэв: Би биш.

20 Мөн хаан хэлэв: Та яаж миний зүрхний бодлуудыг мэдэв? Та зоригтойгоор ярьж болно, мөн энэ зүйлүүдийн талаар надад хэлж болно; мөн түүнчлэн та ямар хүчээр миний сүргийг тараасан ах дүүсийг минь алж мөн гарыг нь тас цавчсан билээ—

21 Мөн эдүгээ, хэрэв та энэ зүйлүүдийн талаар надад хэлэх аваас, таны хүссэн юуг боловч би танд өгнө; мөн хэрэв энэ нь хэрэгтэй бол, би таныг өөрийн их цэргээр сахиуль; гэвч та бол тэд бүгдээс илүү хүчтэйг би мэднэ; гэсэн хэдий ч, надаас таны хүссэн юуг боловч би танд зөвшөөрөх болно.

22 Эдүгээ Аммон зальжин нэгэн; гэвч гэмгүй байсан тул, тэр Лемонайд хэлэв: Хэрэв би ямар хүчээр энэ зүйлийг хийснээ хэлбэл, та миний үгсийг анхааран сонсох уу? Мөн энэ нь танаас миний хүсэх тэр зүйл ажгуу.

23 Мөн хаан түүнд хариулж, мөн хэлэв: Тийм ээ, би таны бүх л үгсэд итгэнэ, мөн тийн тэрээр заль мэхэнд нь автагдсан байв.

24 Мөн Аммон зоригтойгоор түүнд ярьж эхлэв, мөн түүнд хэлсэн нь: Та Бурхан байдагт итгэдэг үү

25 Мөн тэр хариулж, мөн түүнд хэлэв: Тэр нь ямар утгатайг би мэдэхгүй.

And it came to pass that Ammon, being filled with the Spirit of God, therefore he perceived the thoughts of the king. And he said unto him: Is it because thou hast heard that I defended thy servants and thy flocks, and slew seven of their brethren with the sling and with the sword, and smote off the arms of others, in order to defend thy flocks and thy servants; behold, is it this that causeth thy marvelings?

I say unto you, what is it, that thy marvelings are so great? Behold, I am a man, and am thy servant; therefore, whatsoever thou desirest which is right, that will I do.

Now when the king had heard these words, he marvelled again, for he beheld that Ammon could discern his thoughts; but notwithstanding this, king Lamoni did open his mouth, and said unto him: Who art thou? Art thou that Great Spirit, who knows all things?

Ammon answered and said unto him: I am not.

And the king said: How knowest thou the thoughts of my heart? Thou mayest speak boldly, and tell me concerning these things; and also tell me by what power ye slew and smote off the arms of my brethren that scattered my flocks—

And now, if thou wilt tell me concerning these things, whatsoever thou desirest I will give unto thee; and if it were needed, I would guard thee with my armies; but I know that thou art more powerful than all they; nevertheless, whatsoever thou desirest of me I will grant it unto thee.

Now Ammon being wise, yet harmless, he said unto Lamoni: Wilt thou hearken unto my words, if I tell thee by what power I do these things? And this is the thing that I desire of thee.

And the king answered him, and said: Yea, I will believe all thy words. And thus he was caught with guile.

And Ammon began to speak unto him with boldness, and said unto him: Believest thou that there is a God?

And he answered, and said unto him: I do not know what that meaneth.

26 Мөн тэгэхэд нь Аммон хэлэв: Агуу Их Сүнс байдаг та итгэдэг үү

27 Мөн тэр хэлсэн нь, Тийм ээ.

28 Мөн Аммон хэлсэн нь: Энэ бол Бурхан. Мөн Аммон түүнд дахин хэлэв: Бурхан болох тэр Агуу Их Сүнс тэнгэр мөн газарт байдаг бүх зүйлийг бүтээсэн гэдэгт та итгэдэг үү

29 Мөн тэрээр хэлэв: Тийм ээ, газарт буй тэр бүхий л зүйлийг тэр бүтээсэн гэдэгт би итгэдэг; гэвч би тэнгэрийн тухайд мэдэхгүй.

30 Мөн Аммон түүнд хэлсэн нь: Тэнгэр гэдэг нь Бурхан мөн түүний бүх ариун тэнгэр элчүүд оршдог тэр газар бөлгөө.

31 Мөн Лемонай хаан хэлэв: Энэ нь газраас дээгүүр байдаг уу

32 Мөн Аммон хэлэв: Тийм ээ, мөн тэрээр бүх хүмүүний үрсийн дээрээс доош хардаг; мөн тэр бүх зүрхний бодлууд хийгээд санааг мэддэг; учир нь тэд бүгд эхлэлээс түүний мутраар бүтээгдсэн ажгуу.

33 Мөн Лемонай хаан хэлэв: Би таны ярьсан эдгээр зүйлд итгэлээ. Та Бурханаас илгээгдсэн үү

34 Аммон түүнд хэлэв: Би бол хүн; мөн хүмүүн нь эхлэлд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, мөн би бол энэ хүмүүст эдгээр зүйлийг заахаар түүний Ариун Сүнсээр дуудагдсан, тэд шударга бөгөөд үнэн болох тэрхүү мэдлэгт авчрагдаж болохын тулд болой;

35 Мөн мэдлэгийг, мөн түүнчлэн Бурханы талаарх миний итгэл хийгээд хүслийн дагуу хүчийг надад өгдөг Сүнсний хэсэг нь надад оршдог.

36 Эдүгээ Аммон эдгээр үгсийг хэлээд дэлхийн бүтээлт, мөн түүнчлэн Адамын бүтээлтээс эхэлж, мөн түүнд хүмүүний уналтын талаар бүх зүйлийг хэлж, мөн бошиглогчдоор яригдсан хүмүүсийн цэдгүүд болон ариун судруудыг, бүр тэдний эцэг, Иерусалимыг орхисон Лихайн цагийг хүртэлх тэдгээрийг өгүүлж мөн түүний өмнө дэлгэжээ.

37 Мөн тэрээр тэдэнд (тухайлбал хаанд болоод түүний зарц нарт) тэдний эцэг өвгөдийн аглаг буйд дахь бүх аянуудыг, мөн тэдний бүх өлсөж мөн цангасан зовлонгууд, мөн тэдний зүдрэлүүд гэх мэтийг, мөн тийн цааш өгүүлсэн ажгуу.

And then Ammon said: Believest thou that there is a Great Spirit?

And he said, Yea.

And Ammon said: This is God. And Ammon said unto him again: Believest thou that this Great Spirit, who is God, created all things which are in heaven and in the earth?

And he said: Yea, I believe that he created all things which are in the earth; but I do not know the heavens.

And Ammon said unto him: The heavens is a place where God dwells and all his holy angels.

And king Lamoni said: Is it above the earth?

And Ammon said: Yea, and he looketh down upon all the children of men; and he knows all the thoughts and intents of the heart; for by his hand were they all created from the beginning.

And king Lamoni said: I believe all these things which thou hast spoken. Art thou sent from God?

Ammon said unto him: I am a man; and man in the beginning was created after the image of God, and I am called by his Holy Spirit to teach these things unto this people, that they may be brought to a knowledge of that which is just and true;

And a portion of that Spirit dwelleth in me, which giveth me knowledge, and also power according to my faith and desires which are in God.

Now when Ammon had said these words, he began at the creation of the world, and also the creation of Adam, and told him all the things concerning the fall of man, and rehearsed and laid before him the records and the holy scriptures of the people, which had been spoken by the prophets, even down to the time that their father, Lehi, left Jerusalem.

And he also rehearsed unto them (for it was unto the king and to his servants) all the journeyings of their fathers in the wilderness, and all their sufferings with hunger and thirst, and their travail, and so forth.

38 Мөн түүнчлэн тэр Лемен болон Лемүелийн мөн Ишмэилийн хөвгүүдийн эсэргүүцлүүдийн талаар тэдэнд тоочиж, тийм ээ, тэдний бүх эсэргүүцлийг тэрээр тэдэнд өгүүлэв; мөн Лихай Иерусалимыг орхисон цагаас одоо цагийг хүртэлх бүх цэдгүүд болон судруудыг тэр тэдэнд тайлбарлав.

39 Гэвч энэ нь бүгд бус; учир нь тэр тэдэнд дэлхийн үүслээс бэлтгэгдсэн, гэтэлгэлийн төлөвлөгөөг тайлбарлав; мөн түүнчлэн Христийн ирэлтийн талаар тэр тэдэнд мэдүүлж, мөн Их Эзэний бүх ажлыг тэрээр тэдэнд мэдүүлэв.

40 Мөнхүү улиран тохиох дор тэр эдгээр бүх зүйлийг хэлсний, мөн тэдгээрийг хаанд тайлбарласны дараа, хаан түүний бүх үгэнд итгэсэн аж.

41 Мөн тэрээр Их Эзэнд залбирч эхлэн, хэлсэн нь: Ай Их Эзэн, нигүүлсэж соёрхоно уу; Нифайн хүмүүсийн дээр байсан өөрийн өгөөмөр их нигүүлслийнхээ дагуу, надад, мөн миний хүмүүсийн дээр соёрхоно уу.

42 Мөн эдүгээ, тэрээр үүнийг хэлээд тэрээр үхсэн мэт газар унав.

43 Мөнхүү улиран тохиох дор түүний зарц нар түүнийг авч эхнэрт нь хүргэж, мөн орон дээр хэвтүүлэв; мөн тэрээр хоёр өдөр мөн хоёр шөнийн турш үхсэн мэт хэвтэв; мөн леменчүүдийн маягаар, түүнийг алдсанаас асар ихээр гашуудан эхнэр нь мөн хөвгүүд нь мөн охид нь түүний дээр гашуудаж байв.

And he also rehearsed unto them concerning the rebellions of Laman and Lemuel, and the sons of Ishmael, yea, all their rebellions did he relate unto them; and he expounded unto them all the records and scriptures from the time that Lehi left Jerusalem down to the present time.

But this is not all; for he expounded unto them the plan of redemption, which was prepared from the foundation of the world; and he also made known unto them concerning the coming of Christ, and all the works of the Lord did he make known unto them.

And it came to pass that after he had said all these things, and expounded them to the king, that the king believed all his words.

And he began to cry unto the Lord, saying: O Lord, have mercy; according to thy abundant mercy which thou hast had upon the people of Nephi, have upon me, and my people.

And now, when he had said this, he fell unto the earth, as if he were dead.

And it came to pass that his servants took him and carried him in unto his wife, and laid him upon a bed; and he lay as if he were dead for the space of two days and two nights; and his wife, and his sons, and his daughters mourned over him, after the manner of the Lamanites, greatly lamenting his loss.

## Алма 19

- 1 Мөнхүү улиран тохиох дор хоёр өдөр мөн хоёр шөнийн дараа тэд түүний биеийг авч мөн үхэгсдээр оршуулах зорилгын тулд тэдний хийсэн хадан булшинд хэвтүүлэх гэж байв.
- 2 Эдүгээ хатан Аммоны алдрыг сонссон тул, тиймийн тул тэр түүнийг өөр дээрээ ирэхийг хүсэн хүн илгээв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор Аммон зарлиглуулсныхаа дагуу явж, мөн хатанд очиж, мөн түүгээр юу хийлгэх гэснийг тэр мэдэхийг хүсэв.
- 4 Мөн тэрээр түүнд хэлэв: Нөхрийн маань зарц нар таныг ариун Бурханы бошиглогч гэдгийг мөн түүний нэрээр олон гайхамшигт ажлуудыг хийх хүч танд байдгийг надад мэдүүллээ;
- 5 Тиймийн тул, хэрэв энэ нь нөхцөл аваас, би таныг нөхрийг минь очиж үзээсэй хэмээнэ, учир нь тэр орондоо хэвтүүлэгдээд хоёр өдөр мөн хоёр шөнө болж байна; мөн зарим нь түүнийг үхээгүй гэх юм, гэвч бусад зарим нь тэр үхчихсэн мөн тэр өмхийрч байна, мөн тэр хадан булшинд тавигдвал зохино гэх юм; гэвч миний хувьд, өөрт минь бол тэр өмхийрөөгүй.
- 6 Эдүгээ, Аммоны хүссэн нь энэ байв, учир нь Лемонай хаан Бурханы хүчний дор байгааг тэр мэдэж байв; итгэлгүй байдлын харанхуй гивлүүр түүний оюунаас зайлуулагдаж, мөн түүний оюуныг гэрэлтүүлсэн гэрэл, Бурханы алдар суугийн гэрэл болох тэр, мөн түүний сайн сайхны гайхамшигт гэрэл болох тэр—тийм ээ, харанхуйн үүлс ярагдсаны дараа энэ гэрэл түүний бодгальд маш их баяслыг төрүүлснийг мөн үүрдийн амьдралын гэрэл түүний бодгальд гэрэлтсэнийг тэр мэдэж байв, тийм ээ, энэ нь түүний буй биеийг хальж, мөн тэрээр оюун санааныхаа хувьд Бурханаар аваачигдсаныг тэрээр мэдсэн бөлгөө—
- 7 Тиймийн тул, хатны түүнээс хүссэн нь түүний цорын ганц хүсэл байв. Тиймийн тул, тэрээр өөрөөс нь хатны хүссэний дагуу хааныг үзэхээр оров; мөн тэрээр хааныг үзэж, мөн тэрээр түүнийг үхээгүйг мэдэв.

## Alma 19

And it came to pass that after two days and two nights they were about to take his body and lay it in a sepulchre, which they had made for the purpose of burying their dead.

Now the queen having heard of the fame of Ammon, therefore she sent and desired that he should come in unto her.

And it came to pass that Ammon did as he was commanded, and went in unto the queen, and desired to know what she would that he should do.

And she said unto him: The servants of my husband have made it known unto me that thou art a prophet of a holy God, and that thou hast power to do many mighty works in his name;

Therefore, if this is the case, I would that ye should go in and see my husband, for he has been laid upon his bed for the space of two days and two nights; and some say that he is not dead, but others say that he is dead and that he stinketh, and that he ought to be placed in the sepulchre; but as for myself, to me he doth not stink.

Now, this was what Ammon desired, for he knew that king Lamoni was under the power of God; he knew that the dark veil of unbelief was being cast away from his mind, and the light which did light up his mind, which was the light of the glory of God, which was a marvelous light of his goodness—yea, this light had infused such joy into his soul, the cloud of darkness having been dispelled, and that the light of everlasting life was lit up in his soul, yea, he knew that this had overcome his natural frame, and he was carried away in God—

Therefore, what the queen desired of him was his only desire. Therefore, he went in to see the king according as the queen had desired him; and he saw the king, and he knew that he was not dead.

- 8 Мөн тэрээр хатанд хэлэв: Тэр үхээгүй, харин тэр Бурханы хувьд унтаж байна, мөн маргааш тэр дахин босох болно; тиймийн тул түүнийг бүү оршуул.
- 9 Мөн Аммон түүнд хэлэв: Та үүнд итгэв үү? Мөн тэр түүнд хэлэв: Таны үгнээс мөн зарц нарын маань үгнээс өөр гэрч надад үгүй байна; гэсэн хэдий ч би энэ нь таны хэлсний дагуу байх болно хэмээн итгэнэ.
- 10 Мөн Аммон түүнд хэлэв: Үлэмж итгэлийнхээ учир адислагдсан болой та; би танд хэлнэ, эмэгтэй, бүх нифайчуудын хүмүүсийн дунд ч ийм агуу их итгэл үгүй билээ.
- 11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тэр цагаас Аммоны товлосон, түүний босох ёстой маргаашийн тэрхүү цагийг хүртэл нөхрийнхөө орон дээр сахив.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэр Аммоны үгсийн дагуу босов; мөн тэр босохдоо, гараа сайхь эмэгтэйн зүг сунгаж, мөн хэлэв: Бурханы нэр алдаршиг, мөн адислагдсан болой та.
- 13 Учир нь таны амьд нь гарцаагүйн адил, болгоогтун, би өөрийн Гэтэлгэгчийг харав; мөн тэр ирнэ, мөн эмэгтэйгээс төрөн, мөн өөрийнх нь нэрэнд итгэх бүх хүн төрөлхтнийг тэр гэтэлгэх болно. Эдүгээ, тэрээр энэ үгсийг хэлэхдээ, түүний дотор зүрх сэтгэл нь уужирч, мөн тэрээр баяслаасаа болоод дахин унав; мөн түүнчлэн хатан ч унаж, Сүнсээр давамгайлагдаж байсны учир болой.
- 14 Эдүгээ Аммон түүний ах дүүс болох нифайчуудын дунд, эсвээс Бурханы бүх хүмүүсийн дунд өөрсдийн алдсууд хийгээд уламжлалуудын учир тийм их гашуудлын шалтгаан болсон леменчүүдийн дээр Их Эзэний Сүнс түүний залбирлуудын дагуу цутгагдаж буйг хараад, өвдөг дээрээ унаж, мөн түүний ах дүүсийн төлөө хийсэн зүйлийн төлөө Бурханд талархан мөн залбиралд сэтгэл оюунаа уудалж эхлэв; мөн тэрээр түүнчлэн баясалдаа дийлдэн байв; мөн тийн тэд гурвуулаа газарт унав.
- 15 Эдүгээ, хааны зарц нар тэдний унасныг хараад, тэд түүнчлэн Бурханд залбирч эхлэв, учир нь Их Эзэнээс эмээх айдас тэдэнд түүнчлэн ирсэн байв, учир нь хааны өмнө зогсож мөн түүнд Аммоны агуу их хүчний талаар гэрчилсэн тэд байв.

And he said unto the queen: He is not dead, but he sleepeth in God, and on the morrow he shall rise again; therefore bury him not.

And Ammon said unto her: Believest thou this? And she said unto him: I have had no witness save thy word, and the word of our servants; nevertheless I believe that it shall be according as thou hast said.

And Ammon said unto her: Blessed art thou because of thy exceeding faith; I say unto thee, woman, there has not been such great faith among all the people of the Nephites.

And it came to pass that she watched over the bed of her husband, from that time even until that time on the morrow which Ammon had appointed that he should rise.

And it came to pass that he arose, according to the words of Ammon; and as he arose, he stretched forth his hand unto the woman, and said: Blessed be the name of God, and blessed art thou.

For as sure as thou livest, behold, I have seen my Redeemer; and he shall come forth, and be born of a woman, and he shall redeem all mankind who believe on his name. Now, when he had said these words, his heart was swollen within him, and he sunk again with joy; and the queen also sunk down, being overpowered by the Spirit.

Now Ammon seeing the Spirit of the Lord poured out according to his prayers upon the Lamanites, his brethren, who had been the cause of so much mourning among the Nephites, or among all the people of God because of their iniquities and their traditions, he fell upon his knees, and began to pour out his soul in prayer and thanksgiving to God for what he had done for his brethren; and he was also overpowered with joy; and thus they all three had sunk to the earth.

Now, when the servants of the king had seen that they had fallen, they also began to cry unto God, for the fear of the Lord had come upon them also, for it was they who had stood before the king and testified unto him concerning the great power of Ammon.

- 16 Мөнхүү улиран тохиох дор бүр тэд бүгд, Лемен үндэсний Эбиш гэгч нэгэн бүсгүйгээс бусад нь, газарт унах хүртлээ Их Эзэний нэрийг өөрсдийн хүчээр дуудав, тэр бүсгүй эцгийнхээ гайхамшигт үзэгдлийн учир олон жилийн өмнө Их Эзэнд хөрвүүлэгдсэн аж—
- 17 Тийн Их Эзэнд хөрвүүлэгдсэн учир, мөн үүнийг хэзээ ч мэдүүлээгүйн учир, тиймийн тул, тэрээр Лемонийн бүх зарц нар газарт унасныг, мөн түүнчлэн эзэгтэй нь, хатан, мөн хаан, мөн Аммон газарт тэрийн хэвтэхийг хараад, энэ бол Бурханы хүч гэдгийг тэр бүсгүй мэдэв; мөн тэдний дунд тохиолдсоныг хүмүүст мэдүүлснээр, тэд энэ байдлыг болгоогоод энэ боломж нь тэднийг Бурханы хүчинд итгүүлнэ хэмээн бодсон учир, тиймийн тул сайхь бүсгүй байшингаас байшин хүртэл гүйж, үүнийг хүмүүст мэдүүлсээр байв.
- 18 Мөн тэд хааны гэрт өөрсдөө нэгдэн цугларч эхлэв. Мөн олон ард ирж, мөн тэд хааныг мөн хатныг, бас тэдний зарц нар газарт тэрийн хэвтэхийг гайхаж балмагдан харав, мөн тэд бүгд үхсэн мэтээр хэвтэж байв; мөн түүнчлэн тэд Аммоныг харав мөн болгоогтун тэр нь нифай үндэстэн хүн байв.
- 19 Мөн эдүгээ хүмүүс өөр хоорондоо бувтналдаж эхлэв; зарим нь нифай хүн уг нутагт үлдэхийг тэрээр зөвшөөрсөн учир, тэдний дээр, эсвээс хааны мөн түүний гэрийн дээр агуу хилэнц нүүрлэж хэмээцгээв.
- 20 Гэвч бусад зарим нь тэднийг зэмлэж, хэлрүүн: Тэр Себасын усны дэргэд сүргээ тараалгасан зарц нараа алсан учир, хаантан гэрийнхээ дээр энэ хилэнцийг авчирсан ажээ.
- 21 Мөн түүнчлэн тэд Себасын усанд босож мөн хаанд өмчлөгдсөн сүргийг тараасан тэдгээр эрчүүдээр зэмлэгдэв, учир нь хааны сүргийг хамгаалж байхдаа Себасын усанд түүний алсан өөрсдийнх нь ах дүүсийн тооны учир тэд Аммонд уурлаж байв,
- 22 Эдүгээ, ах нь Аммоны илдэнд алагдсан нэг нь, тэр Аммонд үлэмж уурласан учир илдээ сугалж мөн тэрээр үүнийг Аммоны дээр, түүнийг алахаар буулгаж болохын тулд урагшлав; мөн тэрээр түүнийг цохихоор илдээ өргөхөд, болгоогтун, тэр үхэхийн унав.

And it came to pass that they did call on the name of the Lord, in their might, even until they had all fallen to the earth, save it were one of the Lamanitish women, whose name was Abish, she having been converted unto the Lord for many years, on account of a remarkable vision of her father—

Thus, having been converted to the Lord, and never having made it known, therefore, when she saw that all the servants of Lamoni had fallen to the earth, and also her mistress, the queen, and the king, and Ammon lay prostrate upon the earth, she knew that it was the power of God; and supposing that this opportunity, by making known unto the people what had happened among them, that by beholding this scene it would cause them to believe in the power of God, therefore she ran forth from house to house, making it known unto the people.

And they began to assemble themselves together unto the house of the king. And there came a multitude, and to their astonishment, they beheld the king, and the queen, and their servants prostrate upon the earth, and they all lay there as though they were dead; and they also saw Ammon, and behold, he was a Nephite.

And now the people began to murmur among themselves; some saying that it was a great evil that had come upon them, or upon the king and his house, because he had suffered that the Nephite should remain in the land.

But others rebuked them, saying: The king hath brought this evil upon his house, because he slew his servants who had had their flocks scattered at the waters of Sebus.

And they were also rebuked by those men who had stood at the waters of Sebus and scattered the flocks which belonged to the king, for they were angry with Ammon because of the number which he had slain of their brethren at the waters of Sebus, while defending the flocks of the king.

Now, one of them, whose brother had been slain with the sword of Ammon, being exceedingly angry with Ammon, drew his sword and went forth that he might let it fall upon Ammon, to slay him; and as he lifted the sword to smite him, behold, he fell dead.

23 Эдүгээ Аммон алагдахгүйг бид харлаа, учир нь Их Эзэн түүний эцэг Мозаяд ийн хэлсэн ажгуу: Би түүнийг хэлтрүүлэх болно, мөн энэ нь таны итгэлийн дагуу түүнд байх болно—тиймийн тул, Мозая Их Эзэнд түүнийг даатгасан байжээ.

24 Мөнхүү улиран тохиох дор ард олон Аммоныг алахаар илдээ далайсан мөнөөх эр үхэтхийн унахыг болгоогоод, тэд бүгдийн дээр айдас хургаж мөн тэд түүнд эсвээс унасан буй тэдний хэнд нь ч хүрэхээр гарраа хөдөлгөж зүрхэлсэнгүй; мөн тэд дахин өөр хоорондоо юу энэ агуу их хүчийг гаргаж чадахыг эсвээс энэ зүйлүүд ямар утгатай болохыг гайхаж эхлэв.

25 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд Аммон бол Агуу Их Сүнс байсан хэмээн хэлэх нь олон байв, мөн бусад зарим нь Агуу Их Сүнсээр илгээгдсэн хэмээв.

26 Гэвч бусад зарим нь тэднийг бүгдийг зэмлэж, тэр бол нифайчуудаас тэднийг тарчлаахаар илгээгдсэн мангас мөн хэмээв.

27 Мөн тэдний алдсуудын учир тэднийг зовоохоор Аммон Агуу Их Сүнсээр илгээгдсэн хэмээн хэлсэн зарим нь байв; мөн нифайчуудыг үргэлж харж ханддаг, тэднийг өөрсдийг нь гараас ямагт чөлөөлдөг байсан нь Агуу Их Сүнс юм; мөн тэд өөрсдийнх нь ах дүүс болох леменчүүдээс тийм олныг устгасан тэрхүү Агуу Их Сүнс нь энэ байв.

28 Мөн тийн тэдний дундах зөрчилдөөн үлэмж хурц болж эхлэв. Мөн тэд ийн тэмцэлдэж байхад, ард олныг цугларахад хүргэсэн мөнөөх эмэгтэй зарц ирж, ард олны дундах зөрчлийг хараад тэрээр үлэмж харамсан, бүр нулимс унагав.

29 Мөнхүү улиран тохиох дор тэр явж, тэрээр магад түүнийг газраас босгож болохын тулд хатныг гараас нь барив; мөн тэрээр түүнд гар хүрмэгц тэр босож мөн хөл дээрээ зогсов, мөн чанга дуугаар хашгирч хэлэв: Ай алдар нь бадарсан Есүс, намайг аймшигт тамаас аварсан тэр! Ай алдар нь бадарсан Бурхан, энэ хүмүүсийн дээр нигүүлслийг соёрхооч!

Now we see that Ammon could not be slain, for the Lord had said unto Mosiah, his father: I will spare him, and it shall be unto him according to thy faith—therefore, Mosiah trusted him unto the Lord.

And it came to pass that when the multitude beheld that the man had fallen dead, who lifted the sword to slay Ammon, fear came upon them all, and they durst not put forth their hands to touch him or any of those who had fallen; and they began to marvel again among themselves what could be the cause of this great power, or what all these things could mean.

And it came to pass that there were many among them who said that Ammon was the Great Spirit, and others said he was sent by the Great Spirit;

But others rebuked them all, saying that he was a monster, who had been sent from the Nephites to torment them.

And there were some who said that Ammon was sent by the Great Spirit to afflict them because of their iniquities; and that it was the Great Spirit that had always attended the Nephites, who had ever delivered them out of their hands; and they said that it was this Great Spirit who had destroyed so many of their brethren, the Lamanites.

And thus the contention began to be exceedingly sharp among them. And while they were thus contending, the woman servant who had caused the multitude to be gathered together came, and when she saw the contention which was among the multitude she was exceedingly sorrowful, even unto tears.

And it came to pass that she went and took the queen by the hand, that perhaps she might raise her from the ground; and as soon as she touched her hand she arose and stood upon her feet, and cried with a loud voice, saying: O blessed Jesus, who has saved me from an awful hell! O blessed God, have mercy on this people!

- 30 Мөн тэр үүнийг хэлээд, тэр гараа хавсрав, учир нь тэр баяслаар дүүрсэн байж, мөн ойлгогдоогүй олон үгийг ярив; мөн тэрээр үүнийг хийгээд, тэр хаан Лемонайг гараас нь барихад, мөн болгоогтун тэр босож мөн хөл дээрээ зогсов.
- 31 Мөн тэрээр, тэр даруй, өөрийн хүмүүсийн дундах зөрчлийг хараад, явж мөн тэднийг зэмлэж эхлэв, мөн Аммоны амнаас өөрийн дуулсан үгсээ тэдэнд зааж эхлэв; мөн сонссон бүхэн түүний үгсэд итгэж, мөн Их Эзэнд хөрвүүлэгдэв.
- 32 Гэвч тэдний дунд түүний үгсийг сонсохгүй нь олон байв; тиймийн тул тэд өөрсдийн замаар одов.
- 33 Мөнхүү улиран тохиох дор Аммон босоод түүнчлэн тэдэнд туслав, мөн Лемонайн бүх зарц нар түүнчлэн үйлдэв; мөн тэд бүгд хүмүүст нэгэн адил зүйлийг—тэдний зүрх сэтгэл өөрчлөгдсөнийг; тэд хилэнцийг үйлдэх хүсэлгүй болсныг тунхаглав.
- 34 Мөн болгоогтун, олон нь тэд тэнгэр элчүүдийг харсан мөн тэдэнтэй ярилцсан хэмээн хүмүүст тунхаглав; мөн тийн тэд Бурханы мөн түүний зөв шударгын зүйлүүдийг тэдэнд өгүүлэв.
- 35 Мөнхүү улиран тохиох дор тэдний үгсэд итгэсэн олон нь байв; мөн итгэсэн болгон баптисм хүртэв; мөн тэд зөв шударга хүмүүс болж, мөн тэд дундаа сүм байгуулав.
- 36 Мөн тийн Их Эзэний ажил леменчүүдийн дунд үүссэн болой; тийн Их Эзэн өөрийн Сүнсийг тэдний дээр цутгаж эхлэв; мөн наманчилж мөн түүний нэрэнд итгэх бүх хүмүүст түүний мутар сунгаастай байдгийг бид харлаа.

And when she had said this, she clasped her hands, being filled with joy, speaking many words which were not understood; and when she had done this, she took the king, Lamoni, by the hand, and behold he arose and stood upon his feet.

And he, immediately, seeing the contention among his people, went forth and began to rebuke them, and to teach them the words which he had heard from the mouth of Ammon; and as many as heard his words believed, and were converted unto the Lord.

But there were many among them who would not hear his words; therefore they went their way.

And it came to pass that when Ammon arose he also administered unto them, and also did all the servants of Lamoni; and they did all declare unto the people the selfsame thing—that their hearts had been changed; that they had no more desire to do evil.

And behold, many did declare unto the people that they had seen angels and had conversed with them; and thus they had told them things of God, and of his righteousness.

And it came to pass that there were many that did believe in their words; and as many as did believe were baptized; and they became a righteous people, and they did establish a church among them.

And thus the work of the Lord did commence among the Lamanites; thus the Lord did begin to pour out his Spirit upon them; and we see that his arm is extended to all people who will repent and believe on his name.



## Алма 20

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутагт сүм байгуулаад, Лемонай хаан тэрээр түүнийг эцэгтээ үзүүлж болохын тулд Аммоныг түүнтэй хамт Нифайн нутаг тийш явахыг хүсэв.
- 2 Мөн Их Эзэний дуу хоолой Аммонд ирж, хэлрүүн: Чи Нифайн нутаг өөд явах ёсгүй, учир нь болгоогтун, хаан амийг чинь эрэлхийлэх болно; гэвч чи Миддонай нутаг тийш явах ёстой; учир нь болгоогтун, чиний ах Аарон, мөн түүнчлэн Мулокай мөн Амма нар шоронд байна.
- 3 Эдүгээ улиран тохиох дор Аммон үүнийг дуулаад, тэрээр Лемонайд хэлэв: Болгоогтун, ах минь мөн ах дүүс минь Миддонай дахь шоронд байна, мөн би тэднийг чөлөөлж болохын тулд би явна.
- 4 Эдүгээ Лемонай Аммонд хэлэв: Би мэднэ, Их Эзэний хүчинд та бүх зүйлийг хийж чадна. Гэвч болгоогтун, би тангай Миддонай нутгийн зүг явах болно; учир нь Миддонай нутгийн хаан, Антиомно нэртэй нэгэн, надад найз минь билээ; тиймийн тул би Миддонай нутгийн зүг явна, би уг нутгийн хааныг зусардаж болохын тулд, мөн тэрээр таны ах дүүсийг шоронгоос гаргах болно. Эдүгээ Лемонай түүнд хэлэв: Ах дүүсийг тань шоронд буйг танд хэн хэлэв
- 5 Мөн Аммон түүнд хэлэв: Бурханаас өөр хэн ч надад хэлсэнгүй; мөн тэр надад—Яв мөн ах дүүсээ чөлөөл, учир нь тэд Миддонай нутаг дахь шоронд байна хэмээсэн хэллээ.
- 6 Эдүгээ Лемонай үүнийг дуулаад тэрээр зарц нараараа морьд мөн сүйх тэргээ бэлэн болгуулав.
- 7 Мөн тэрээр Аммонд хэлсэн нь: Ирэгтүн, би тангай хамт Миддонай нутаг уруу явах болно, мөн таны ах дүүсийг шоронгоос гаргахыг хаанаас нь би гуйх болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Аммон, Лемонай нар тийш аялах зуураа, тэд бүх нутгийн дээрх хаан болох Лемонайн эцэгтэй уулзав.
- 9 Мөн болгоогтун, Лемонайн эцэг түүнд хэлж: Би өөрийн хөвгүүд, мөн өөрийн хүмүүст зориулан хийсэн зоогийн их өдөр та нар яагаад зоогонд ирсэнгүй вэ

## Alma 20

And it came to pass that when they had established a church in that land, that king Lamoni desired that Ammon should go with him to the land of Nephi, that he might show him unto his father.

And the voice of the Lord came to Ammon, saying: Thou shalt not go up to the land of Nephi, for behold, the king will seek thy life; but thou shalt go to the land of Middoni; for behold, thy brother Aaron, and also Muloki and Ammah are in prison.

Now it came to pass that when Ammon had heard this, he said unto Lamoni: Behold, my brother and brethren are in prison at Middoni, and I go that I may deliver them.

Now Lamoni said unto Ammon: I know, in the strength of the Lord thou canst do all things. But behold, I will go with thee to the land of Middoni; for the king of the land of Middoni, whose name is Antiomno, is a friend unto me; therefore I go to the land of Middoni, that I may flatter the king of the land, and he will cast thy brethren out of prison. Now Lamoni said unto him: Who told thee that thy brethren were in prison?

And Ammon said unto him: No one hath told me, save it be God; and he said unto me—Go and deliver thy brethren, for they are in prison in the land of Middoni.

Now when Lamoni had heard this he caused that his servants should make ready his horses and his chariots.

And he said unto Ammon: Come, I will go with thee down to the land of Middoni, and there I will plead with the king that he will cast thy brethren out of prison.

And it came to pass that as Ammon and Lamoni were journeying thither, they met the father of Lamoni, who was king over all the land.

And behold, the father of Lamoni said unto him: Why did ye not come to the feast on that great day when I made a feast unto my sons, and unto my people?

10 Мөн түүнчлэн тэр хэлэв: Худалчийн хүүхдүүдийн нэг болох энэ нифай үндэсний эртэй чи хаачихнав

11 Мөнхүү улиран тохиох дор Лемонай хааш явж байгаага түүнд тоочин хэлэв, учир нь тэр түүнийг гомдоохоос эмээсэн ажээ.

12 Мөн түүнчлэн түүний бэлтгэсэн эцгийнхээ зоогонд очоогүйн шалтгаан, түүний өөрийнх нь хаант улсад түүнийг саатуулсан бүх учрыг тэрээр түүнд хэлэв.

13 Мөн эдүгээ Лемонай түүнд эдгээр бүх зүйлийг тоочиход, болгоогтун, түүний гайхлыг төрүүлж, эцэг нь түүнд уурлаж, мөн хэлэв: Лемонай чи худалчийн хөвгүүд болох эдгээр нифайчуудыг чөлөөлүүлэх гэж явна. Болгоогтун, тэр худалч чинь бидний эцэг өвгөдийг дээрэмдсэн; мөн эдүгээ түүний хүүхдүүд түүнчлэн тэд өөрсдийн башир арга мөн өөрсдийн худал хуурмагаараа тэд биднээс бидний хөрөнгийг дээрэмдэж болохын тулд биднийг мэхэлж болохын тулд бидний дунд иржээ.

14 Эдүгээ Лемонайн эцэг түүнд тэрээр Аммоныг илдээр алахыг зарлиглав. Мөн түүнчлэн тэрээр тэр Миддонай нутаг тийш явах ёсгүй, харин тэр өөртэй нь хамт Ишмэилийн нутагт буцах ёстой хэмээн түүнд зарлиглав.

15 Гэвч Лемонай түүнд хэлэв: Би Аммоныг алахгүй бас Ишмэилийн нутагт ч буцахгүй, харин би Аммоны ах дүүсийг суллуулж болохын тулд Миддонай нутаг тийш явна, учир нь тэд бол шударга эрчүүд мөн үнэн Бурханы ариун бошиглогчид гэдгийг би мэднэ.

16 Эдүгээ түүний эцэг эдгээр үгийг дуулаад, тэрээр түүнд уурлаж, мөн тэр түүнийг цохин газарт унагаж болохын тулд илдээ сугалав.

17 Гэвч Аммон урагш зогсож мөн түүнд хэлэв: Болгоогтун, та хүүгээ алах ёсгүй; гэсэн хэдий ч, та наас илүү тэр унавал дээр, учир нь болгоогтун, тэр нүглүүдээ наманчилсан; харин хэрэв та энэ цагт, уур хилэндээ байхад унах юм бол, бодгаль тань аврагдаж чадахгүй.

And he also said: Whither art thou going with this Nephite, who is one of the children of a liar?

And it came to pass that Lamoni rehearsed unto him whither he was going, for he feared to offend him.

And he also told him all the cause of his tarrying in his own kingdom, that he did not go unto his father to the feast which he had prepared.

And now when Lamoni had rehearsed unto him all these things, behold, to his astonishment, his father was angry with him, and said: Lamoni, thou art going to deliver these Nephites, who are sons of a liar. Behold, he robbed our fathers; and now his children are also come amongst us that they may, by their cunning and their lyings, deceive us, that they again may rob us of our property.

Now the father of Lamoni commanded him that he should slay Ammon with the sword. And he also commanded him that he should not go to the land of Middoni, but that he should return with him to the land of Ishmael.

But Lamoni said unto him: I will not slay Ammon, neither will I return to the land of Ishmael, but I go to the land of Middoni that I may release the brethren of Ammon, for I know that they are just men and holy prophets of the true God.

Now when his father had heard these words, he was angry with him, and he drew his sword that he might smite him to the earth.

But Ammon stood forth and said unto him: Behold, thou shalt not slay thy son; nevertheless, it were better that he should fall than thee, for behold, he has repented of his sins; but if thou shouldst fall at this time, in thine anger, thy soul could not be saved.

18 Мөн үүнчлэн, та түдгэлзэх нь зүйд нийцнэ, учир нь хэрэв та хүүгээ албал, тэр гэмгүй хүн байсны учир, түүний цус газраас Их Эзэн Бурхандаа хашгирч, өшөөг нь таны дээр ирүүлэхийн учир болой; мөн та сүнсээ ч алдаж болзошгүй.

19 Эдүгээ Аммон эдгээр үгийг түүнд хэлэхэд, тэр түүнд хариулж, хэлрүүн: Хэрэв би хүүгээ алах аваас би гэмгүй цусыг урсгах болно гэдгээ мэднэ; учир нь түүнийг устгахыг эрэлхийлсэн нь та болой.

20 Мөн тэрээр Аммоныг алахаар гараа сунгав. Гэвч Аммон түүний дайралтыг тогтоож мөн үүнчлэн тэр хэрэглэж чадахгүй болгож гарыг нь цохив.

21 Эдүгээ Аммон өөрийг нь алж чадахыг хаан хараад, тэрээр амиа хэлтрүүлэхийг Аммоноос гуйж эхлэв.

22 Гэвч Аммон илдээ өргөж, мөн түүнд хэлэв: Болгоогтун, миний ах дүүс шоронгоос гаргагдах болно гэдгийг та зөвшөөрөхгүй бол би таныг цохих болно.

23 Эдүгээ хаан, тэрээр амиа алдах нь хэмээн айсан учир, хэлсэн нь: Хэрэв та намайг хэлтрүүлбэл би юу гуйсныг тань, бүр хаант улсынхаа хагасыг ч танд олгох болно гэв.

24 Эдүгээ Аммон өвгөн хаанд хүслийнхээ дагуу нөлөөлснөө хараад, тэрээр түүнд хэлсэн нь: Хэрэв та ах дүүс минь шоронгоос гаргагдаж болохыг, мөн үүнчлэн Лемонай өөрийн хаант улсыг хадгалж болохыг, мөн та түүнд үл дургүйцэж, харин тэр хүслийнхээ дагуу юу бодсоноо хийж болохыг түүнд зөвшөөрвөл, тэгвэл би таныг хэлтрүүлэх болно; үгүй бол би таныг газарт нам дарах болно.

25 Эдүгээ Аммон эдгээр үгийг хэлэхэд, хаан амийнхаа тул баясаж эхлэв.

26 Мөн Аммон өөрийг нь устгах хүсэлгүй байгааг тэр хараад, мөн үүнчлэн тэр өөрийнх нь хүү Лемонайд их хайртайг хараад, тэр үлэмж гайхан балмагдаж, мөн хэлэв: Би таны ах дүүсийг чөлөөлж мөн хүү Лемонайдаа хаант улсаа хадгалахыг зөвшөөрөх нь таны бүх хүсэл учир, болгоогтун, миний хүү хаант улсаа энэ цагаас мөн үүрд хадгалж болохыг би зөвшөөрч байна; мөн би түүнийг хойшид захирах нь үгүй—

And again, it is expedient that thou shouldst forbear; for if thou shouldst slay thy son, he being an innocent man, his blood would cry from the ground to the Lord his God, for vengeance to come upon thee; and perhaps thou wouldst lose thy soul.

Now when Ammon had said these words unto him, he answered him, saying: I know that if I should slay my son, that I should shed innocent blood; for it is thou that hast sought to destroy him.

And he stretched forth his hand to slay Ammon. But Ammon withstood his blows, and also smote his arm that he could not use it.

Now when the king saw that Ammon could slay him, he began to plead with Ammon that he would spare his life.

But Ammon raised his sword, and said unto him: Behold, I will smite thee except thou wilt grant unto me that my brethren may be cast out of prison.

Now the king, fearing he should lose his life, said: If thou wilt spare me I will grant unto thee whatsoever thou wilt ask, even to half of the kingdom.

Now when Ammon saw that he had wrought upon the old king according to his desire, he said unto him: If thou wilt grant that my brethren may be cast out of prison, and also that Lamoni may retain his kingdom, and that ye be not displeased with him, but grant that he may do according to his own desires in whatsoever thing he thinketh, then will I spare thee; otherwise I will smite thee to the earth.

Now when Ammon had said these words, the king began to rejoice because of his life.

And when he saw that Ammon had no desire to destroy him, and when he also saw the great love he had for his son Lamoni, he was astonished exceedingly, and said: Because this is all that thou hast desired, that I would release thy brethren, and suffer that my son Lamoni should retain his kingdom, behold, I will grant unto you that my son may retain his kingdom from this time and forever; and I will govern him no more—

27 Мөн түүнчлэн би таны ах дүүс шоронгоос гаргагдаж болохыг, мөн та болон ах дүүс тань над дээр мийн хаант улсад ирж болохыг зөвшөөрье; учир нь би таныг харахыг маш ихээр хүсэх болно. Учир нь хаан түүний ярьсан мөн түүнчлэн өөрийн хүү Лемонайгаар яригдсан үгсэд ихээр гайхаж балмагдсан ажгуу, тиймийн тул тэрээр тэдгээрийг мэдэх хүсэлтэй байв.

28 Мөнхүү улиран тохиох дор Аммон, Лемонай нар өөрсдийн Миддони нутгийн зүг аянаа үргэлжлүүлэв. Мөн Лемонай уг нутгийн хааны мэлмийд тааллыг олжээ; тиймийн тул Аммоны ах дүүс шоронгоос гаргагдаж авчрагдав.

29 Мөн Аммон тэдэнтэй уулзахдаа тэр үлэмж харамсав, учир нь болгоогтун тэд нүцгэн мөн бөх олсоор хүлэгдсэн учир арьс нь үлэмж гэмтсэн байв. Мөн тэд түүнчлэн өлсгөлөн, харангадалт, мөн бүхий л төрлийн зовлонгуудыг тэвчсэн байв; гэсэн хэдий ч тэд бүх зовлонгууддаа тэвчээртэй байжээ.

30 Мөн тохиолдлоор, илүү хатуу мөн илүү зөрүүд хүмүүсийн гарт орсон нь тэдний хувь тавилан байжээ; тиймийн тул тэд тэдний үгийг дуулахгүй байсан аж, мөн тэд тэднийг хөөж, мөн тэднийг цохьсон аж, мөн тэднийг байшингаас байшинд, газраас газарт хүртэл, бүр тэд Миддони нутагт хүрч ирэх хүртэл хэсүүлсэн байв; мөн тэнд тэд баривчлагдаж, мөн шоронд хаягдаж, мөн бөх олсоор хүлэгдэж, тэгээд олон хоногийн турш шоронд хоригдсон ажээ, мөн Лемонай, Аммон хоёроор чөлөөлөгдсөн болой.

And I will also grant unto thee that thy brethren may be cast out of prison, and thou and thy brethren may come unto me, in my kingdom; for I shall greatly desire to see thee. For the king was greatly astonished at the words which he had spoken, and also at the words which had been spoken by his son Lamoni, therefore he was desirous to learn them.

And it came to pass that Ammon and Lamoni proceeded on their journey towards the land of Middoni. And Lamoni found favor in the eyes of the king of the land; therefore the brethren of Ammon were brought forth out of prison.

And when Ammon did meet them he was exceedingly sorrowful, for behold they were naked, and their skins were worn exceedingly because of being bound with strong cords. And they also had suffered hunger, thirst, and all kinds of afflictions; nevertheless they were patient in all their sufferings.

And, as it happened, it was their lot to have fallen into the hands of a more hardened and a more stiff-necked people; therefore they would not hearken unto their words, and they had cast them out, and had smitten them, and had driven them from house to house, and from place to place, even until they had arrived in the land of Middoni; and there they were taken and cast into prison, and bound with strong cords, and kept in prison for many days, and were delivered by Lamoni and Ammon.

*Аарон, мөн Мулокай мөн тэдний ах дүүс леменчүүдэд номлосон тухай шастир оршвой.*

## Алма 21

- 1 Эдүгээ Аммон мөн түүний ах дүүс леменчүүдийн нутгийн хил дээр салцгаахад, болгоогтун, Аарон леменчүүдээр эцэг өвгөдийнхөө унасан нутгийн нэрээр Иерусалим гэж нэрлэгдсэн нутгийн зүг аянаа хөөв; мөн энэ нь Мормоны хилийн ойролцоо зайдуу оршиж байв.
- 2 Эдүгээ леменчүүд мөн амалекайчууд мөн Амюлоны хүмүүс Иерусалим гэж нэрлэгдсэн их хотыг барьсан байв.
- 3 Эдүгээ леменчүүд өөрсдөө хангалттай хатуу, гэвч амалекайчууд мөн амюлончууд бүр илүү хатуу байв; тиймийн тул леменчүүдийг тэд зүрх сэтгэлээ хатууруулж, тэд ёс бусад мөн өөрсдийнх нь жигшүүрт хэргүүдэд тэд илүү хүчтэй болгож байв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор Аарон Иерусалим хотод ирж, мөн эхлээд амалекайчуудад номлож эхлэв. Мөн тэрээр өөрсдийнх нь синагогуудад тэдэнд номлож эхлэв, учир нь тэд нихоруудын жаягийн дагуу синагогуудыг барьсан байв; учир нь амалекайчууд мөн амюлончуудын олон нь нихоруудын жаягийн дагуу байв.
- 5 Тиймийн тул, Аарон тэдний синагогуудын нэгэнд нь хүмүүст номлохоор ороход, мөн тэдэнд ярьж байхад, болгоогтун нэг амалекай үндэсний хүн босож мөн түүнтэй маргаж эхлэв, хэлрүүн: Таны гэрчилсэн чинь юу билээ? Та тэнгэр элчийг харсан гэж үү? Тэнгэр элчүүд яагаад бидэнд үзэгддэггүй вэ? Болгоогтун энэ хүмүүс таны хүмүүс шиг сайн биш хэрэг үү
- 6 Түүнчлэн, бид наманчлахгүй аваас бид эрсдэх болно хэмээн та хэллээ. Та яаж бидний зүрхэн дэх бодол хийгээд зорилгыг мэдэв? Бидэнд наманчлах шалтгаан буйг та яаж мэдэв? Та яаж бид зөв шударга хүмүүс бус гэдгийг мэдэв? Болгоогтун, бид дуганууд барьж, мөн бид Бурханыг бишрэн сүсэглэхээр өөрсдөө цугларцгаадаг. Бурхан бүх хүмүүнийг аврах болно гэдэгт бид итгэдэг.

*An account of the preaching of Aaron, and Muloki, and their brethren, to the Lamanites.*

## Alma 21

Now when Ammon and his brethren separated themselves in the borders of the land of the Lamanites, behold Aaron took his journey towards the land which was called by the Lamanites, Jerusalem, calling it after the land of their fathers' nativity; and it was away joining the borders of Mormon.

Now the Lamanites and the Amalekites and the people of Amulon had built a great city, which was called Jerusalem.

Now the Lamanites of themselves were sufficiently hardened, but the Amalekites and the Amulonites were still harder; therefore they did cause the Lamanites that they should harden their hearts, that they should wax strong in wickedness and their abominations.

And it came to pass that Aaron came to the city of Jerusalem, and first began to preach to the Amalekites. And he began to preach to them in their synagogues, for they had built synagogues after the order of the Nehors; for many of the Amalekites and the Amulonites were after the order of the Nehors.

Therefore, as Aaron entered into one of their synagogues to preach unto the people, and as he was speaking unto them, behold there arose an Amalekite and began to contend with him, saying: What is that thou hast testified? Hast thou seen an angel? Why do not angels appear unto us? Behold are not this people as good as thy people?

Thou also sayest, except we repent we shall perish. How knowest thou the thought and intent of our hearts? How knowest thou that we have cause to repent? How knowest thou that we are not a righteous people? Behold, we have built sanctuaries, and we do assemble ourselves together to worship God. We do believe that God will save all men.

- 7 Эдүгээ Аарон түүнд хэлэв: Бурханы Хүү хүн төрөлхтнийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирэх болно гэдэгт та итгэдэг үү
- 8 Мөн нөгөөх хүн түүнд хэлэв: Бид таныг нэг ч ийм зүйл мэддэг гэдэгт итгэхгүй байна. Бид эдгээр мунхаг уламжлалд итгэхгүй байна. Ирэх зүйлүүдийн тухай мэддэг, бас таны эцэг өвгөд мөн түүнчлэн бидний эцэг өвгөд өөрсдийнхөө ярьдаг байсан зүйлийн талаар, ирэх түүний талаар мэддэг байсан гэдэгт бид итгэдэггүй.
- 9 Эдүгээ Аарон тэдэнд Христийн ирэлтийн талаар, мөн түүнчлэн нас барагсдын амилуулалтын талаарх судруудыг, мөн Христийн зовлон хийгээд үхэл, мөн түүний цусны цагаатгалаар бус аваас хүн төрөлхтний төлөө гэтэлгэл байж чадахгүй байсан тухай тэдэнд дэлгэж эхлэв.
- 10 Мөнхүү улиран тохиох дор тэр эдгээр зүйлийг тэдэнд тайлбарлаж эхлэхэд тэд түүнд уурлаж, мөн түүнийг дооглож эхлэв; мөн тэд түүний ярьсан үгсийг сонсохоос татгалзсан ажээ.
- 11 Тиймийн тул, тэрээр тэд түүний үгсийг сонсохоос татгалзсаныг хараад, тэр тэдний синагогоос гарч одов, мөн Анай-Антай гэж нэрлэгдсэн тосгонд ирж, мөн тэнд Мулокай тэдэнд номлож байхыг мөн түүнчлэн Амма мөн түүний ах дүүсийг тэр олов. Мөн тэд үгийн тухай олон хүмүүстэй маргалдав.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэд зүрх сэтгэлээ хатууруулах хүмүүс гэдгийг харж, тиймийн тул тэд одож мөн Миддони нутагт хүрч ирэв. Мөн тэд үгийг олонд номлов, мөн тэдний заасан үгсэд итгэсэн нь цөөн байв.
- 13 Гэсэн хэдий ч, Аарон мөн хэдэн тооны түүний ах дүүс баривчлагдаж мөн шоронд хаягдав, мөн тэднээс үлдсэн нь Миддони нутгаас гарч эргэн тойрны газруудад зугтан гарав.
- 14 Мөн шоронд хаягдсан тэд олон зүйлийг тэвчиж, мөн тэд Лемонай Аммон хоёрын гараар чөлөөлөгдөж, мөн тэднийг хооллож мөн хувцаслав.
- 15 Мөн тэд дахин үгийг тунхаглахаар явж мөн тийн тэд эхнийхээ удаа шоронгоос чөлөөлөгдөв; мөн тийн тэд зовсон байв.

Now Aaron said unto him: Believest thou that the Son of God shall come to redeem mankind from their sins?

And the man said unto him: We do not believe that thou knowest any such thing. We do not believe in these foolish traditions. We do not believe that thou knowest of things to come, neither do we believe that thy fathers and also that our fathers did know concerning the things which they spake, of that which is to come.

Now Aaron began to open the scriptures unto them concerning the coming of Christ, and also concerning the resurrection of the dead, and that there could be no redemption for mankind save it were through the death and sufferings of Christ, and the atonement of his blood.

And it came to pass as he began to expound these things unto them they were angry with him, and began to mock him; and they would not hear the words which he spake.

Therefore, when he saw that they would not hear his words, he departed out of their synagogue, and came over to a village which was called Ani-Anti, and there he found Muloki preaching the word unto them; and also Ammah and his brethren. And they contended with many about the word.

And it came to pass that they saw that the people would harden their hearts, therefore they departed and came over into the land of Middoni. And they did preach the word unto many, and few believed on the words which they taught.

Nevertheless, Aaron and a certain number of his brethren were taken and cast into prison, and the remainder of them fled out of the land of Middoni unto the regions round about.

And those who were cast into prison suffered many things, and they were delivered by the hand of Lamoni and Ammon, and they were fed and clothed.

And they went forth again to declare the word, and thus they were delivered for the first time out of prison; and thus they had suffered.

- 16 Мөн тэд Их Эзэний Сүнсээр удирдагдсан зүг рүү хааш боловч явж, амалекайчуудын синагог бүрд, эсвээс тэд орох зөвшөөрлийг олж чадах леменчүүдийн цуглаан бүр дээр Бурханы үгийг номлов.
- 17 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн тэднийг адисалж эхлэв, үүний хэрээр тэд олныг үнэний мэдлэгт авчирсан бөлгөө; тийм ээ, тэд олонд өөрсдийнх нь нүглүүдийн, мөн эцэг өвгөдийнх нь зөв бус уламжлалуудын талаар итгүүлжээ.
- 18 Мөнхүү улиран тохиох дор Аммон Лемонай хоёр Миддони нутгаас тэдний өвлөж авсан нутаг асан Ишмэилийн нутагт эргэж ирэв.
- 19 Мөн Лемонай хаан Аммон өөрт нь үйлчлэхийг, өөрөөр хэлбэл түүний зарц байхыг зөвшөөрөхгүй байлаа.
- 20 Харин тэрээр Ишмэилийн нутагт синагогууд баригдах болгов; мөн тэрээр энэ хүмүүсийг, өөрөөр хэлбэл түүний засаглалд байсан хүмүүсийг нэгдэн цугларцаах болгов.
- 21 Мөн тэрээр тэдний тул баясаж, мөн тэрээр тэдэнд олон зүйлийг заав. Мөн түүнчлэн түүний захиргаандахь хүмүүс гэдгийг, мөн тэд чөлөөт хүмүүс байсныг, тэд түүний эцэг болох хааны дарлалаас чөлөөлөгдсөнийг тэдэнд тунхаглав; учир нь түүний эцэг тэрээр Ишмэилийн нутагт мөн эргэн тойрных нь бүх нутагт байсан хүмүүсийн дээр түүнийг засаглаж болохыг зөвшөөрсөн байв.
- 22 Мөн түүнчлэн тэр тэдэнд Их Эзэн өөрсдийн Бурханыг хүслийнхээ дагуу ямар ч газар байсан, хэрэв энэ нь Лемонай хааны засаглалын доорх нутаг аваас чөлөөтэй шүтэн бишрэх эрхийг эдэлж болохыг тунхаглав.
- 23 Мөн Аммон Лемонай хааны хүмүүст номлов; мөнхүү улиран тохиох дор тэрээр тэдэнд зөв шударгад хамаарах бүх зүйлүүдийн талаар заасан болой. Мөн тэр байдгаараа хичээнгүйлэн өдөр бүр тэдэнд ухуулж байв; мөн тэд түүний үгсэд анхааран хандаж, мөн тэд Бурханы зарлигуудыг дагахдаа мэриймтгий байв.

And they went forth whithersoever they were led by the Spirit of the Lord, preaching the word of God in every synagogue of the Amalekites, or in every assembly of the Lamanites where they could be admitted.

And it came to pass that the Lord began to bless them, insomuch that they brought many to the knowledge of the truth; yea, they did convince many of their sins, and of the traditions of their fathers, which were not correct.

And it came to pass that Ammon and Lamoni returned from the land of Middoni to the land of Ishmael, which was the land of their inheritance.

And king Lamoni would not suffer that Ammon should serve him, or be his servant.

But he caused that there should be synagogues built in the land of Ishmael; and he caused that his people, or the people who were under his reign, should assemble themselves together.

And he did rejoice over them, and he did teach them many things. And he did also declare unto them that they were a people who were under him, and that they were a free people, that they were free from the oppressions of the king, his father; for that his father had granted unto him that he might reign over the people who were in the land of Ishmael, and in all the land round about.

And he also declared unto them that they might have the liberty of worshiping the Lord their God according to their desires, in whatsoever place they were in, if it were in the land which was under the reign of king Lamoni.

And Ammon did preach unto the people of king Lamoni; and it came to pass that he did teach them all things concerning things pertaining to righteousness. And he did exhort them daily, with all diligence; and they gave heed unto his word, and they were zealous for keeping the commandments of God.

## Алма 22

- 1 Эдүгээ, Аммон Лемонайн хүмүүст үргэлжлүүлэн тийн зааж байх зуур, Аарон болон түүний ах дүүсийн шастирт бид эргэж орёе; учир нь тэрбээр Миддони нутгаас одсоныхоо дараа тэр Сүнсээр Нифайн нутаг тийш, бүр Ишмэилийн нутгаас бусад бүх нутгийн дээрх тэр хааны голомт уруу удирдагдсан буюу; мөн тэр нь Лемонайн эцэг байв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хааны ордонд ах дүүсийнхээ хамт түүнд очиж, мөн хааны өмнө бөхийн, мөн түүнд хэлэв: Болгоогтун, Ай хаантан, бид Аммоны ах дүүс, шоронгоос таны чөлөөлсөн тэд билээ.
- 3 Мөн эдүгээ, Ай хаантан, хэрэв та бидний амийг хэлтрүүлж хайрлавал бид таны зарц нар болно. Мөн хаан тэдэнд хэлсэн нь: Босогтун, учир нь би та нарт амийг чинь хэлтрүүлэх болно, мөн би та нарыг өөрийн зарц нар байхыг зөвшөөрөхгүй; харин би надад сургахыг та нараас шаардана; учир нь та нарын ах Аммоны үгсийн өгөөмөр мөн агуугийн учир сэтгэл оюундаа зарим талаар би түгшиж байна; мөн тэр яагаад та нартай Миддонигаас ирээгүйн шалтгааныг би мэдэхийг хүсч байна.
- 4 Мөн Аарон хаанд хэлэв: Болгоогтун, Их Эзэний Сүнс түүнийг өөр зүгт дуудсан; тэрээр Ишмэилийн нутаг тийш Лемонайн хүмүүст заахаар явсан билээ.
- 5 Эдүгээ хаан тэдэнд хэлэв: Их Эзэний Сүнсний талаар та нарын хэлсэн тань юу билээ? Болгоогтун энэ бол намайг түгшээх тэр зүйл болой.
- 6 Мөн түүнчлэн, Аммон хэлсэн нь—Хэрэв та нар наманчилбал аврагдах болно, мөн хэрэв та нар наманчлахгүй бол, та нар эцсийн өдөр зайлуулагдах болно гэсэн нь юу вэ
- 7 Мөн Аарон түүнд хариулж мөн түүнд хэлэв: Бурхан байдагт та итгэдэг үү? Мөн хаан хэлэв: Амалекайчууд Бурхан байдаг хэмээн хэлдгийг би мэднэ, мөн тэд түүнийг шүтэн бишрэхээр өөрсдөө цугларцгааж болохын тулд тэд дуганууд барихыг би тэдэнд зөвшөөрсөн бөлгөө. Мөн хэрэв эдүгээ та Бурхан байдаг гэж хэлбэл, болгоогтун би итгэх болно.

## Alma 22

Now, as Ammon was thus teaching the people of Lamoni continually, we will return to the account of Aaron and his brethren; for after he departed from the land of Middoni he was led by the Spirit to the land of Nephi, even to the house of the king which was over all the land save it were the land of Ishmael; and he was the father of Lamoni.

And it came to pass that he went in unto him into the king's palace, with his brethren, and bowed himself before the king, and said unto him: Behold, O king, we are the brethren of Ammon, whom thou hast delivered out of prison.

And now, O king, if thou wilt spare our lives, we will be thy servants. And the king said unto them: Arise, for I will grant unto you your lives, and I will not suffer that ye shall be my servants; but I will insist that ye shall administer unto me; for I have been somewhat troubled in mind because of the generosity and the greatness of the words of thy brother Ammon; and I desire to know the cause why he has not come up out of Middoni with thee.

And Aaron said unto the king: Behold, the Spirit of the Lord has called him another way; he has gone to the land of Ishmael, to teach the people of Lamoni.

Now the king said unto them: What is this that ye have said concerning the Spirit of the Lord? Behold, this is the thing which doth trouble me.

And also, what is this that Ammon said—If ye will repent ye shall be saved, and if ye will not repent, ye shall be cast off at the last day?

And Aaron answered him and said unto him: Believest thou that there is a God? And the king said: I know that the Amalekites say that there is a God, and I have granted unto them that they should build sanctuaries, that they may assemble themselves together to worship him. And if now thou sayest there is a God, behold I will believe.



8 Мөн эдүгээ Аарон үүнийг дуулж, зүрх нь баясаж эхлэв, мөн тэр хэлсэн нь: Болгоогтун, та амьд буй нь гарцаагүйн адил, Ай хаантан, Бурхан байдаг.

9 Мөн хаан хэлэв: Бурхан гэж бидний эцэг өвгөдийг Иерусалим нутгаас авчирсан тэр Агуу Их Сүнс мөн үү

10 Мөн Аарон түүнд хэлэв: Тийм ээ, тэр бол Агуу Их Сүнс, бас тэрээр тэнгэр ба газар аль алинд нь буй бүх зүйлийг бүтээсэн юм. Та үүнд итгэдэг үү

11 Мөн тэр хэлэв: Тийм ээ, Агуу Их Сүнс бүх зүйлийг бүтээсэн гэдэгт би итгэдэг, мөн та нарыг надад эдгээр бүх зүйлийн талаар хэлж өгөхийг би хүсч байна, мөн би таны үгсэд итгэх болно.

12 Мөнхүү улиран тохиох дор хаан түүний үгсэд итгэхийг Аарон үзээд, тэрээр Адамын бүтээлтээс эхэлж, судруудыг—Бурхан хэрхэн хүнийг өөрийн дүр төрхөөр бүтээсэн хийгээд Бурхан түүнд зарлигууд өгснийг, мөн зөрчлийн учир хүмүүн унасныг хаанд уншиж өгөв.

13 Мөн Аарон судруудыг Адамын бүтээлтээс эхлэн түүнд тайлбарлаж, хүмүүний уналтыг, мөн тэдний эгэл байдал хийгээд түүнчлэн дэлхийн үүслээс бэлтгэгдсэн, түүний нэрэнд итгэсэн хэнд боловч бүгдийн төлөө байдаг, Христээр дамжин ирэх гэтэлгэлийн төлөвлөгөөг түүний өмнө дэлгэсэн болой.

14 Мөн хүн нэгэнт унаснаас хойш тэрээр өөрөөсөө болоод юуг ч хүртэх нь зохистой байж чадахгүй; гэвч Христийн зовлонгууд хийгээд үхэл нь тэдний нүглийг итгэл болон наманчлал зэргээр дамжуулан цагаатгадаг; мөн тэрээр үхлийн хүлээсийг тасчиж, ингэснээр булш ялалт үгүй болж, мөн үхлийн шаналал нь сүр жавхланд найдах найдвараар уужруулагдсан билээ; мөн Аарон эдгээр бүх зүйлийг хаанд тайлбарласан аж.

And now when Aaron heard this, his heart began to rejoice, and he said: Behold, assuredly as thou livest, O king, there is a God.

And the king said: Is God that Great Spirit that brought our fathers out of the land of Jerusalem?

And Aaron said unto him: Yea, he is that Great Spirit, and he created all things both in heaven and in earth. Believest thou this?

And he said: Yea, I believe that the Great Spirit created all things, and I desire that ye should tell me concerning all these things, and I will believe thy words.

And it came to pass that when Aaron saw that the king would believe his words, he began from the creation of Adam, reading the scriptures unto the king—how God created man after his own image, and that God gave him commandments, and that because of transgression, man had fallen.

And Aaron did expound unto him the scriptures from the creation of Adam, laying the fall of man before him, and their carnal state and also the plan of redemption, which was prepared from the foundation of the world, through Christ, for all whosoever would believe on his name.

And since man had fallen he could not merit anything of himself; but the sufferings and death of Christ atone for their sins, through faith and repentance, and so forth; and that he breaketh the bands of death, that the grave shall have no victory, and that the sting of death should be swallowed up in the hopes of glory; and Aaron did expound all these things unto the king.

15 Мөнхүү улиран тохиох дор Аарон эдгээр зүйлийг түүнд тайлбарласны дараа, хаан хэлэв: Таны ярьсан тэрхүү мөнх амьдралыг авч болохын тулд би юу хийх билээ? Тийм ээ, энэ ёс бусын сүнсийг цээжнээсээ үндсээр нь сугалуулан, мөн Бурханаар төрж болохын тулд, мөн түүний Сүнсийг хүлээн авч, баяслаар дүүргэгдэж болохын тулд, эцсийн өдөр би зайлуулагдахгүй байж болохын тулд би юу хийх билээ? Болгоогтун, тэр хэлэв, би энэхүү агуу баяслыг хүлээн авч болохын тулд би өөрийн эзэмшдэг бүгдийг өгөх болно, тийм ээ, би хаант улсаа орхих болно.

16 Гэвч Аарон түүнд хэлэв: Хэрэв та энэ зүйлийг хүсвэл, хэрэв та Бурханы өмнө доош бөхийх юм бол, тийм ээ, хэрэв та бүх нүглүүдээ наманчилбал, мөн Бурханы өмнө доош бөхийвөл, та хүлээн авах болно гэдэгтээ найдсаар, мөн итгэлтэйгээр түүний нэрийг дуудвал, тэгвэл та хүссэн тэрхүү найдварыг хүлээн авах болно.

17 Мөнхүү улиран тохиох дор Аарон эдгээр үгсийг хэлэхэд, хаан Их Эзэний өмнө доош бөхийн өвдөг дээрээ сөхрөв; тийм ээ, бүр тэрээр газар дээр сунаан хэвтэж, мөн хүчтэйгээр хашгирч, хэлсэн нь:

18 Ай Бурхан, Бурхан байдаг хэмээн Аарон надад хэлэв; мөн хэрэв Бурхан байдаг бол, мөн хэрэв та Бурхан бол, та өөрийгөө надад мэдүүлнэ үү, мөн би таныг мэдэхийн тулд мөн би нас барагсдаас босгогдож, мөн эцсийн өдөр аврагдаж болохын тулд би бүх нүглүүдээ орхих болно. Мөн эдүгээ хаан эдгээр үгийг хэлээд, тэр үхсэн мэт цочирдон унав.

19 Мөнхүү улиран тохиох дор зарц нар нь гүйлдэж мөн хаанд тохиолдсон бүгдийг хатанд хэлэв. Мөн тэр хаан дээр ирэв; мөн тэр түүнийг үхсэн мэт хэвтэж буйг, мөн түүнчлэн Аарон болон түүний ах дүүс түүний унагаагдсаны шалтгаан мэт зогсохыг хараад, тэр тэдэнд уурлаж, мөн тэднийг баривчилж мөн тэднийг алахыг зарц нартаа, эсвээс хааны зарц нарт зарлиглав.

20 Эдүгээ зарц нар хааны унасан шалтгааныг харсан байв, тиймийн тул тэд Аарон болон түүний ах дүүст гар хүрч зүрхэлсэнгүй; мөн тэд хатныг гуйж хэлсэн нь: Болгоогтун, та яагаад тэдний нэг нь л бид бүгдээс илүү хүчтэй байхад бид энэ хүмүүсийг алахыг бидэнд зарлиглав? Тиймийн тул бид тэдний өмнө унах болно.

And it came to pass that after Aaron had expounded these things unto him, the king said: What shall I do that I may have this eternal life of which thou hast spoken? Yea, what shall I do that I may be born of God, having this wicked spirit rooted out of my breast, and receive his Spirit, that I may be filled with joy, that I may not be cast off at the last day? Behold, said he, I will give up all that I possess, yea, I will forsake my kingdom, that I may receive this great joy.

But Aaron said unto him: If thou desirest this thing, if thou wilt bow down before God, yea, if thou wilt repent of all thy sins, and will bow down before God, and call on his name in faith, believing that ye shall receive, then shalt thou receive the hope which thou desirest.

And it came to pass that when Aaron had said these words, the king did bow down before the Lord, upon his knees; yea, even he did prostrate himself upon the earth, and cried mightily, saying:

O God, Aaron hath told me that there is a God; and if there is a God, and if thou art God, wilt thou make thyself known unto me, and I will give away all my sins to know thee, and that I may be raised from the dead, and be saved at the last day. And now when the king had said these words, he was struck as if he were dead.

And it came to pass that his servants ran and told the queen all that had happened unto the king. And she came in unto the king; and when she saw him lay as if he were dead, and also Aaron and his brethren standing as though they had been the cause of his fall, she was angry with them, and commanded that her servants, or the servants of the king, should take them and slay them.

Now the servants had seen the cause of the king's fall, therefore they durst not lay their hands on Aaron and his brethren; and they pled with the queen saying: Why commandest thou that we should slay these men, when behold one of them is mightier than us all? Therefore we shall fall before them.

21 Эдүгээ хатан зарц нарын айдсыг хараад түүнчлэн өөр дээр нь ямар нэгэн хилэнц ирэх буюу хэмээн өөрөө ч үлэмж айж эхлэв. Мөн зарц нартаа явж мөн хүмүүсийг дуудахыг тэр тэдэнд зарлиглав, Аарон болон түүний ах дүүсийг тэд алж болохын тулд болой.

22 Эдүгээ Аарон хатны шийдэмгий байдлыг хараад, тэрээр, түүнчлэн хүмүүсийн зүрх сэтгэлийн хатууг мэдэхийн учир, ард олон нэгдэн чуулах буюу хэмээн, мөн тэдний дунд агуу тэмцэл мөн зөрчил байх вий хэмээн айв; тиймийн тул тэрээр гараа сунган хааныг газраас босгож, мөн түүнд хэлэв: Бос. Мөн тэрээр хүчээ олж, хөл дээрээ зогсов.

23 Эдүгээ энэ нь хатан болон зарц нарын олон нь байхад хийгдсэн бөлгөө. Мөн тэд үүнийг хараад ихээр гайхаж, мөн айж эхлэв. Мөн хаан урагш алхаж, мөн тэдэнд тохинуулж эхлэв. Мөн тэрээр тэдэнд тохинуулж, үүний хэрээр бүх гэрийнхэн нь Их Эзэнд хөрвүүлэгдэв.

24 Эдүгээ хатны зарлигийн учир ард олон нэгдэн цугларч, мөн Аарон болон түүний ах дүүсийн учир тэдний дунд маш их бувтналдаан байж эхлэв.

25 Гэвч хаан тэдний дунд алхан орж мөн тэдэнд тохиулав. Мөн тэд Аарон болон түүнтэй хамт байсан тэдний тухайд тайтгаруулагдав.

26 Мөнхүү улиран тохиох дор хаан хүмүүсийн тайвширсныг хараад, тэрээр Аарон болон түүний ах дүүсийг ард олны дунд зогсоод, мөн тэд уг үгийг тэдэнд номлох болгов.

27 Мөнхүү улиран тохиох дор хаан бүх нутаг даяар, мөн Мантайн хилийг даган, дорноос өрнөдөд урсах Сидон голын эхийн дэргэд, Зарахемла нутгийн умардад байх аглаг буйдын хилд, дорнын тэнгисээс бүр өрнийн тэнгис хүртэл үргэлжилдэг, мөн тэнгисийн эргийн эргэн тойрон дахь тэрхүү аглаг буйдын нарийн хэсгээр Зарахемла нутгаас тусгаарлагддаг байсан дорнодод мөн өрнөдөд, бүр тэнгистэй хиллэсэн эргэн тойрны бүх нутгуудад, өөрийн бүх нутагт байсан өөрийн бүх хүмүүсийн дунд тунхаг илгээв— мөн тийн леменчүүд болон нифайчууд хуваагддаг байжээ.

Now when the queen saw the fear of the servants she also began to fear exceedingly, lest there should some evil come upon her. And she commanded her servants that they should go and call the people, that they might slay Aaron and his brethren.

Now when Aaron saw the determination of the queen, he, also knowing the hardness of the hearts of the people, feared lest that a multitude should assemble themselves together, and there should be a great contention and a disturbance among them; therefore he put forth his hand and raised the king from the earth, and said unto him: Stand. And he stood upon his feet, receiving his strength.

Now this was done in the presence of the queen and many of the servants. And when they saw it they greatly marveled, and began to fear. And the king stood forth, and began to minister unto them. And he did minister unto them, insomuch that his whole household were converted unto the Lord.

Now there was a multitude gathered together because of the commandment of the queen, and there began to be great murmurings among them because of Aaron and his brethren.

But the king stood forth among them and administered unto them. And they were pacified towards Aaron and those who were with him.

And it came to pass that when the king saw that the people were pacified, he caused that Aaron and his brethren should stand forth in the midst of the multitude, and that they should preach the word unto them.

And it came to pass that the king sent a proclamation throughout all the land, amongst all his people who were in all his land, who were in all the regions round about, which was bordering even to the sea, on the east and on the west, and which was divided from the land of Zarahemla by a narrow strip of wilderness, which ran from the sea east even to the sea west, and round about on the borders of the seashore, and the borders of the wilderness which was on the north by the land of Zarahemla, through the borders of Manti, by the head of the river Sidon, running from the east towards the west—and thus were the Lamanites and the Nephites divided.

- 28 Эдүгээ, леменчүүдийн илүү залхаг хэсэг нь аглаг буйдад амьдарч, мөн майханд оршдог байв; мөн тэд Нифайн нутагт, өрнөдийн аглаг буйд даяар тархсан байв; тийм ээ, мөн түүнчлэн Зарахемла нутгийн өрнөдөд, тэнгисийн эргээр хиллэн, мөн Нифайн нутаг дахь өрнөдөд, өөрсдийн эцэг өвгөдийнхөө анхны өвийн газар, мөн тийн тэнгисийн эргийн дагуу хиллэж байв.
- 29 Мөн түүнчлэн нифайчууд тэднийг тийш түрсэн тэнд олон леменчүүд дорнын тэнгисийн эргээр байв. Мөн тийн нифайчууд бараг л леменчүүдээр хүрээлүүлсэн байлаа; гэсэн хэдий ч Нифайчууд аглаг буйдтай хиллэх умардын, Сидон голын эхэнд, дорноос өрнийг хүртэл, аглаг буйдаар хүрээлүүлэх бүх нутгийг эзэмшин авсан байв; умардад, тэд өөрсдийн Өгөөмөр гэж нэрлэсэн бүр тэр нутгийг хүртэл ирсэн буюу.
- 30 Мөнхүү тэр нь Эзгүйрэл гэж тэдний нэрлэсэн тэр нутагтай хиллэдэг байв, учир нь умардад маш хол орших энэ нь хүмүүсээр эзэмшигдээд мөн устгагдсан тэр нутагт хүрэх, энэ нь тэдний анх буусан газар байсан тул Зарахемлагийн хүмүүсээр олж нээгдсэн газар, тэдний ясных нь тухай бидний ярьсан тэр газар болой.
- 31 Мөн тэндээс өгсөн тэд өмнөд аглаг буйдад ирсэн ажээ. Тийн умард зүгийн нутаг Эзгүйрэл хэмээн нэрлэгдэж, мөн өмнө зүгийн нутаг нь Өгөөмөр хэмээн нэрлэгдсэн ажгуу, төрөл бүрийн зэрлэг амьтдын зүйл бүрээр дүүргэгдсэн аглаг буйд байв, мөн зарим нь умард нутгаас хоол хайж ирсэн ажээ.
- 32 Мөн эдүгээ, Өгөөмөр Эзгүйрэлтэй залгах хилээр, өрнөөс дорнын тэнгисийг хүртэл нифай үндэстэн хүний хувьд зөвхөн бүтэн хагас өдөр аялах зай байв; мөн тийн Нифайн нутаг мөн Зарахемла нутаг бараг л усаар хүрээлэгдэж, өмнөд хэсгийн нутаг мөн умард хэсгийн нутгийн хооронд жижиг хүзүүвч газар байв.
- 33 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд Өгөөмөр нутгийг эзэмшсэн байв, бүр өрнөөс дорнын тэнгисийг хүртэл, мөн тийн нифайчууд өөрсдийн мэргэн ухаанд, харуулууд мөн их цэргээр, леменчүүдийг өмнөдөд шахсан байлаа, тиймээс тэд нь умардад хойшид эзэмшилтэй байхгүйн тулд, тэд умард хэсгийн нутгийг тархан эзэмшихгүйн тулд болой.

Now, the more idle part of the Lamanites lived in the wilderness, and dwelt in tents; and they were spread through the wilderness on the west, in the land of Nephi; yea, and also on the west of the land of Zarahemla, in the borders by the seashore, and on the west in the land of Nephi, in the place of their fathers' first inheritance, and thus bordering along by the seashore.

And also there were many Lamanites on the east by the seashore, whither the Nephites had driven them. And thus the Nephites were nearly surrounded by the Lamanites; nevertheless the Nephites had taken possession of all the northern parts of the land bordering on the wilderness, at the head of the river Sidon, from the east to the west, round about on the wilderness side; on the north, even until they came to the land which they called Bountiful.

And it bordered upon the land which they called Desolation, it being so far northward that it came into the land which had been peopled and been destroyed, of whose bones we have spoken, which was discovered by the people of Zarahemla, it being the place of their first landing.

And they came from there up into the south wilderness. Thus the land on the northward was called Desolation, and the land on the southward was called Bountiful, it being the wilderness which is filled with all manner of wild animals of every kind, a part of which had come from the land northward for food.

And now, it was only the distance of a day and a half's journey for a Nephite, on the line Bountiful and the land Desolation, from the east to the west sea; and thus the land of Nephi and the land of Zarahemla were nearly surrounded by water, there being a small neck of land between the land northward and the land southward.

And it came to pass that the Nephites had inhabited the land Bountiful, even from the east unto the west sea, and thus the Nephites in their wisdom, with their guards and their armies, had hemmed in the Lamanites on the south, that thereby they should have no more possession on the north, that they might not overrun the land northward.

34 Тиймийн тул леменчүүд зөвхөн Нифайн нутаг мөн эргэн тойрных нь аглаг буйдаас өөрийг эзэмшдэггүй байв, мөн эргэн тойронд нь аглаг буйд байлаа. Эдүгээ энэ нь нифайчуудын мэргэн ухаан—леменчүүд тэдний дайсан байсан учир өөрсдийг нь тал бүрээр зовоосныг тэд хүлцэхгүй байх сан, мөн түүнчлэн тэд өөрсдийн хүслүүдийн дагуу тийш зугтаж болох нутагтай байж болохын тулд болой.

35 Мөн эдүгээ би, үүнийг хэлснийхээ дараа, Аммон болоод Аарон, Омнер болон Химнай, мөн тэдний ах дүүсийн шастирт дахин эргэж оръё.

Therefore the Lamanites could have no more possessions only in the land of Nephi, and the wilderness round about. Now this was wisdom in the Nephites—as the Lamanites were an enemy to them, they would not suffer their afflictions on every hand, and also that they might have a country whither they might flee, according to their desires.

And now I, after having said this, return again to the account of Ammon and Aaron, Omner and Himni, and their brethren.

## Алма 23

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор леменчүүдийн хаан өөрийн бүх хүмүүсийн дунд тунхаг илгээж, тэдний нутгийн аль ч хэсэгт, тэд ямар ч газар байсан тэд Аммон, эсвээс Аарон, эсвээс Омнер, эсвээс Химнай, мөн Бурханы үгийг номлож яваа тэдний ах дүүсийн хэнд ч гар хүрэх ёсгүй хэмээв.
- 2 Тийм ээ, тэднийг хүлэхээр, эсвээс тэднийг шоронд хорихоор тэд гараа хүргэх ёсгүй; бас тэд тэдэн дээр нулимж, бас тэднийг цохиж, бас тэднийг синагогуудаасаа хөөж, мөн тэднийг шилбүүрдэх ёсгүй; бас тэд тэдний зүг чулуу шидэх ёсгүй, харин тэд тэдний байшингуудад мөн түүнчлэн тэдний ариун сүмүүд, мөн дугануудад чөлөөтэй нэвтрэх боломжтой хэмээх тогтоолыг тэрээр тэдний дунд илгээсэн бөлгөө.
- 3 Мөн тийн тэд хүссэнийхээ дагуу явж мөн үгийг номлож болно, учир нь хаан, мөн бүх гэрийнхэн нь Их Эзэнд хөрвүүлэгдсэн байв; тиймийн тул тэрээр өөрийн тунхаглалыг өөрийн хүмүүст уг нутаг даяар, Бурханы үг ямар ч саадгүй байж болохын тулд, харин энэ нь бүх нутаг даяар түгэж, түүний хүмүүс эцэг өвгөдийнхөө ёс бус уламжлалуудын талаар ойлгож болохын тулд, мөн тэд бүгд ах дүүс учир, мөн тэд алах, бас тонох, бас хулгайлах, бас садар самууныг үйлдэх, бас ямар ч төрлийн ёс бусыг үйлдэх ёсгүйг ойлгож болохын тулд тунхаглал илгээсэн буюу.
- 4 Мөн эдүгээ улиран тохиох дор хаан энэ тунхаглалыг илгээхэд, Аарон болон түүний ах дүүс хотоос хотод, мөн шүтлэгийн нэг өргөөнөөс нөгөөд явж, сүмүүд байгуулан, мөн леменчүүдийн дунд уг нутаг даяар, тэдний дунд Бурханы үгийг номлуульж мөн заалгахаар санваартнууд хийгээд багш нарыг томилж байв; мөн тийн тэд агуу амжилттай байж эхлэв.
- 5 Мөн мянга мянга нь Их Эзэний мэдлэгт авчрагдав, тийм ээ, мянга мянга нь Нифайчуудын уламжлалд итгэх итгэлд авчрагдсан бөлгөө; мөн тэд одоо цагийг хүртэл доош гардуулагдаж ирсэн тэрхүү цэдгүүд хийгээд бошиглолуудад сургагдав.

## Alma 23

Behold, now it came to pass that the king of the Lamanites sent a proclamation among all his people, that they should not lay their hands on Ammon, or Aaron, or Omner, or Himni, nor either of their brethren who should go forth preaching the word of God, in whatsoever place they should be, in any part of their land.

Yea, he sent a decree among them, that they should not lay their hands on them to bind them, or to cast them into prison; neither should they spit upon them, nor smite them, nor cast them out of their synagogues, nor scourge them; neither should they cast stones at them, but that they should have free access to their houses, and also their temples, and their sanctuaries.

And thus they might go forth and preach the word according to their desires, for the king had been converted unto the Lord, and all his household; therefore he sent his proclamation throughout the land unto his people, that the word of God might have no obstruction, but that it might go forth throughout all the land, that his people might be convinced concerning the wicked traditions of their fathers, and that they might be convinced that they were all brethren, and that they ought not to murder, nor to plunder, nor to steal, nor to commit adultery, nor to commit any manner of wickedness.

And now it came to pass that when the king had sent forth this proclamation, that Aaron and his brethren went forth from city to city, and from one house of worship to another, establishing churches, and consecrating priests and teachers throughout the land among the Lamanites, to preach and to teach the word of God among them; and thus they began to have great success.

And thousands were brought to the knowledge of the Lord, yea, thousands were brought to believe in the traditions of the Nephites; and they were taught the records and prophecies which were handed down even to the present time.

- 6 Мөн итгэсэн болгон нь, өөрөөр хэлбэл Аммон болон түүний ах дүүсийн номлолоор, илчлэлт хийгээд бошиглолын суу билгийн, мөн тэднээр дамжуулан гайхамшгуудыг үйлдэх Бурханы хүчний дагуу үнэний мэдлэгт авчрагдсан болгон нь—тийм ээ, би та нарт хэлнэ, Их Эзэн амьдын адил, тэдний номлолд итгэн мөн Их Эзэнд хөрвүүлэгдсэн леменчүүд болгон, Их Эзэн амьд нь гарцаагүйн адил хэзээ ч итгэл алдраагүй нь гарцаагүй.
- 7 Учир нь тэд зөв шударга хүмүүс болсон билээ; тэд Бурханы эсрэг бас ах дүүсийнхээ хэнийх нь ч эсрэг дахин тулалдахгүйн тулд тэд эсэргүүцлийн зэр зэвсгээ доош тавьсан билээ.
- 8 Эдүгээ, Их Эзэнд хөрвүүлэгдсэн нь тэд юм:
- 9 Ишмэил нутагт байсан леменчүүдийн хүмүүс;
- 10 Мөн түүнчлэн Миддони нутагт байсан леменчүүдийн хүмүүсээс;
- 11 Мөн түүнчлэн Нифайн хотод байсан леменчүүдийн хүмүүсээс;
- 12 Мөн түүнчлэн Шиломын нутагт байсан, Шимлоны нутагт байсан, мөн Лемүелийн хотод, мөн Шимнеломын хот дахь тэр леменчүүдийн хүмүүсээс болой.
- 13 Мөн тэд бол Их Эзэнд хөрвүүлэгдсэн леменчүүдийн хотуудын нэрс болой; мөн тэд эсэргүүцлийн зэр зэвсгээ, тийм ээ, бүх дайны зэр зэвсгээ доош тавьсан тэд, ажээ; мөн тэд бүгдээрээ леменчүүд байв.
- 14 Мөн амалекайчууд нэгээс бусад нь, бас амюлончуудаас нэг нь ч хөрвүүлэгдсэнгүй; харин тэд, өөрсдийн оршдог нутгийн энэ хэсэгт хаа боловч, тийм ээ, мөн тэдний бүх тосгод мөн тэдний бүх хотуудад өөрсдийн зүрх сэтгэлийг, мөн түүнчлэн леменчүүдийн зүрх сэтгэлийг хатууруулсан ажээ.
- 15 Тиймийн тул, тэд наманчилж мөн үнэний мэдлэгт ирж, мөн хөрвүүлэгдсэн леменчүүдийн бүх хотыг бид дурдав.

And as sure as the Lord liveth, so sure as many as believed, or as many as were brought to the knowledge of the truth, through the preaching of Ammon and his brethren, according to the spirit of revelation and of prophecy, and the power of God working miracles in them—yea, I say unto you, as the Lord liveth, as many of the Lamanites as believed in their preaching, and were converted unto the Lord, never did fall away.

For they became a righteous people; they did lay down the weapons of their rebellion, that they did not fight against God any more, neither against any of their brethren.

Now, these are they who were converted unto the Lord:

The people of the Lamanites who were in the land of Ishmael;

And also of the people of the Lamanites who were in the land of Middoni;

And also of the people of the Lamanites who were in the city of Nephi;

And also of the people of the Lamanites who were in the land of Shilom, and who were in the land of Shemlon, and in the city of Lemuel, and in the city of Shimnilom.

And these are the names of the cities of the Lamanites which were converted unto the Lord; and these are they that laid down the weapons of their rebellion, yea, all their weapons of war; and they were all Lamanites.

And the Amalekites were not converted, save only one; neither were any of the Amulonites; but they did harden their hearts, and also the hearts of the Lamanites in that part of the land wheresoever they dwelt, yea, and all their villages and all their cities.

Therefore, we have named all the cities of the Lamanites in which they did repent and come to the knowledge of the truth, and were converted.

16 Мөн эдүгээ улиран тохиох дор хаан мөн хөрвүүлэгдсэн тэд түүгээр ах дүүсээсээ ялгагдаж болохын тулд нэртэй байх хүсэлтэй байв; тиймийн тул хаан Ааронтой болон тэдний санваартнуудын олонтой нь, тэд ялгагдаж болохын тулд тэд өөрсдийн дээр авах ёстой нэрийн талаар зөвлөлдөв.

17 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн нэрсийг Антай-нифай-лихайчууд хэмээв; мөн тэд энэ нэрээр нэрлэгдэж мөн цаашид леменчүүд гэж нэрлэгдсэнгүй.

18 Мөн тэд маш их ажилсаг хүмүүс болж эхлэв; тиймээ, мөн тэд нифайчуудтай нөхөрсөг байв; тиймийн тул, тэд тэдэнтэй харилцааг нээж, мөн Бурханы зүхэл тэднийг цаашид дагасангүй.

And now it came to pass that the king and those who were converted were desirous that they might have a name, that thereby they might be distinguished from their brethren; therefore the king consulted with Aaron and many of their priests, concerning the name that they should take upon them, that they might be distinguished.

And it came to pass that they called their names Anti-Nephi-Lehies; and they were called by this name and were no more called Lamanites.

And they began to be a very industrious people; yea, and they were friendly with the Nephites; therefore, they did open a correspondence with them, and the curse of God did no more follow them.



## Алма 24

- 1 Мөнхүү улиран тохиох дор Амюлоны нутагт байсан мөн Хилом нутаг дахь, мөн Иерусалим нутагт байсан, эцэст нь, эргэн тойрны бүх нутаг дахь, өөрсөд дээрээ Антай-Нифай-Лихай нэрийг аваагүй мөн хөрвүүлэгдээгүй амалекайчууд мөн амюлончууд мөн леменчүүд, амалекайчуудаар мөн амюлончуудаар ах дүүсийнхээ эсрэг уур хилэнд өдөөн хатгагдав.
- 2 Мөн тэдний занал тэдний эсрэг үлэмж хүчтэй болж, бүр үүний хэрээр тэд хааныхаа өөдөөс эсэргүүцэж эхлэв, үүний хэрээр тэд түүнийг өөрсдийн хаан байлгахыг хүсэхгүй байв; тиймийн тул, тэд Антай-Нифай-Лихайн хүмүүсийн эсрэг зэвсэглэв.
- 3 Эдүгээ хаан хүүгийнхээ дээр хаант улсыг шилжүүлж, мөн тэрээр хүүгийнхээ нэрийг Антай-Нифай-Лихай хэмээн нэрлэв.
- 4 Мөн леменчүүд Бурханы хүмүүсийн эсрэг дайнд бэлтгэл хийж эхэлсэн мөнхүү жил хаан хальж одов.
- 5 Эдүгээ Аммон болон түүний ах дүүс мөн түүнтэй хамт ирсэн тэд бүгд өөрсдийнх нь ах дүүсийг устгах гэсэн леменчүүдийн бэлтгэлийг үзээд, тэд Мидиан нутагт ирж, мөн тэнд Аммон бүх ах дүүстэйгээ уулзав; мөн тэндээсээ тэд Лемонай болон түүнчлэн түүний дүү Антай-Нифай-Лихайтай тэд леменчүүдээс өөрсдийгөө хамгаалахад юу хийвэл зохих талаар зөвлөлдөөн хийж болохын тулд Ишмэилийн нутагт ирсэн ажгуу.
- 6 Эдүгээ Их Эзэнд хөрвүүлэгдсэн бүх хүмүүсийн дунд ах дүүсийнхээ эсрэг зэвсэг барих нэг ч бодгаль байсангүй; үгүй, тэд дайнд бүр ямар ч бэлтгэл хийхгүй байв; тийм ээ, мөн түүнчлэн хаан нь тэд тэгэх ёсгүйг тэдэнд зарлиглав.
- 7 Эдүгээ, эдгээр нь уг хэргийн талаар хүмүүст хэлсэн түүний үгс болой: Би Бурхандаа талархана, хайрт хүмүүс минь, бидний агуу их Бурхан сайн сайхны төлөө эдгээр ах дүүсийг маань, нифайчуудыг, бидэнд номлуулж, мөн ёс бус эцэг өвгөдийн маань уламжлалуудыг бидэнд ойлгуулахаар бидэнд илгээсний учир болой.

## Alma 24

And it came to pass that the Amalekites and the Amulonites and the Lamanites who were in the land of Amulon, and also in the land of Helam, and who were in the land of Jerusalem, and in fine, in all the land round about, who had not been converted and had not taken upon them the name of Anti-Nephi-Lehi, were stirred up by the Amalekites and by the Amulonites to anger against their brethren.

And their hatred became exceedingly sore against them, even insomuch that they began to rebel against their king, insomuch that they would not that he should be their king; therefore, they took up arms against the people of Anti-Nephi-Lehi.

Now the king conferred the kingdom upon his son, and he called his name Anti-Nephi-Lehi.

And the king died in that selfsame year that the Lamanites began to make preparations for war against the people of God.

Now when Ammon and his brethren and all those who had come up with him saw the preparations of the Lamanites to destroy their brethren, they came forth to the land of Midian, and there Ammon met all his brethren; and from thence they came to the land of Ishmael that they might hold a council with Lamoni and also with his brother Anti-Nephi-Lehi, what they should do to defend themselves against the Lamanites.

Now there was not one soul among all the people who had been converted unto the Lord that would take up arms against their brethren; nay, they would not even make any preparations for war; yea, and also their king commanded them that they should not.

Now, these are the words which he said unto the people concerning the matter: I thank my God, my beloved people, that our great God has in goodness sent these our brethren, the Nephites, unto us to preach unto us, and to convince us of the traditions of our wicked fathers.

- 8 Мөн болгоогтун, тэрээр бид эдгээр ах дүүс, нифайчуудтай харилцааг нээхийн тулд, бидний зүрхийг зөөллөхөөр бидэнд өөрийн Сүнсний хэсгийг өгсөнд нь би агуу их Бурхандаа талархана.
- 9 Мөн болгоогтун, энэ харилцааг нээснээр бид нүглүүдээ, мөн өөрсдийн үйлдсэн олон аллагыг ойлгонсоноо би түүнчлэн Бурхандаа талархана.
- 10 Мөн түүнчлэн би Бурхандаа талархана, тийм ээ, агуу их Бурхандаа, тэрээр эдгээр зүйлийг наманчилж болохыг бидэнд зөвшөөрсөнд нь, мөн түүнчлэн тэрээр бидний үйлдсэн олон нүглийг мөн аллагуудыг маань өршөөсөнд нь мөн өөрийн Хүүгийн сайн үйлээр, бидний зүрх сэтгэлээс гэмийг зайлуулан авсанд нь талархана.
- 11 Мөн эдүгээ болгоогтун, ах дүүс минь, бидний хийж чадах бүхэн нь (бид бүх хүн төрөлхтнөөс хамгийн төөрөлдсөн нь байсан учир) өөрсдийн бүх нүглийг мөн үйлдсэн бүх аллагуудаа наманчилж, мөн Бурханаар тэдгээрийг зүрх сэтгэлээсээ зайлуулан авахуулах учраас, тодруулбал бидний хийж чадах бүхэн нь Бурханы өмнө тэрээр бидний толбыг зайлуулахуйц хангалттайгаар наманчлах явдал юм—
- 12 Эдүгээ, хамгийн хайрт ах дүүс минь, Бурхан бидний толбуудыг зайлуулан авч, мөн илднүүд маань өнгөлөг болсон учир, тиймээс ах дүүсийнхээ цусаар илднүүдээ хойшид толботуулахгүй байцгаая.
- 13 Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй, илднүүдээ ах дүүсийнхээ цусанд толботуулалгүй хадгалцгаая; учир нь магадгүй, хэрэв бид илдээ дахин толботуулах аваас тэдгээр нь агуу их Бурханы маань Хүүгийн бидний нүглүүдийн цагаатгалын улмаас урсах цусаар дахин өнгөлөгдөн угаагдах боломжгүй байх болно.
- 14 Мөн агуу их Бурхан бидний дээр нигүүлсэнгүй байж, мөн бид мөхөхгүйн тулд эдгээр зүйлийг бидэнд мэдүүлсэн билээ; тийм ээ, мөн тэрээр эдгээр зүйлийг урьдчилан бидэнд мэдүүлсэн юм, яагаад гэвэл тэрээр хүүхдүүдэд маань хайртайн адил бидний бодгальд ч бас хайртай; тиймийн тул, ирээдүйн үеүдийн адил бидэнд ч авралын төлөвлөгөө мэдүүлэгдэж болохын тулд өөрийн нигүүлсэлд тэрээр тэнгэр элчүүдээрээ бидэнд айлчилдаг.

And behold, I thank my great God that he has given us a portion of his Spirit to soften our hearts, that we have opened a correspondence with these brethren, the Nephites.

And behold, I also thank my God, that by opening this correspondence we have been convinced of our sins, and of the many murders which we have committed.

And I also thank my God, yea, my great God, that he hath granted unto us that we might repent of these things, and also that he hath forgiven us of those our many sins and murders which we have committed, and taken away the guilt from our hearts, through the merits of his Son.

And now behold, my brethren, since it has been all that we could do (as we were the most lost of all mankind) to repent of all our sins and the many murders which we have committed, and to get God to take them away from our hearts, for it was all we could do to repent sufficiently before God that he would take away our stain—

Now, my best beloved brethren, since God hath taken away our stains, and our swords have become bright, then let us stain our swords no more with the blood of our brethren.

Behold, I say unto you, Nay, let us retain our swords that they be not stained with the blood of our brethren; for perhaps, if we should stain our swords again they can no more be washed bright through the blood of the Son of our great God, which shall be shed for the atonement of our sins.

And the great God has had mercy on us, and made these things known unto us that we might not perish; yea, and he has made these things known unto us beforehand, because he loveth our souls as well as he loveth our children; therefore, in his mercy he doth visit us by his angels, that the plan of salvation might be made known unto us as well as unto future generations.

15 Ай, бидний Бурхан хичнээн нигүүлсэнгүй билээ! Мөн эдүгээ болгоогтун, бид өөрсдөөсөө толбуудыг зайлуулан авахуулах нь бидний хийж чадах бүх зүйл байлаа, мөн бидний илд өнгөлөг болгогдсон учир, эцсийн өдөр, өөрөөр хэлбэл бид түүний өмнө шүүгдэхийн тулд зогсохоор авчрагдах тэр өдөр, тэрээр өөрийн үгийг бидэнд түгээж мөн түүгээрээ биднийг цэвэр болгосноос хойш бид илдээ ах дүүсийнхээ цусанд толботуулаагүйн гэрчлэл, тэдгээр нь Бурханд маань гэрчлэл болж, өнгөлөг хэвээрээ хадгалагдаж болохын тулд тэдгээрийг далдлан нууцгаая.

16 Мөн эдүгээ, ах дүүс минь, хэрэв бидний ах дүүс биднийг устгахыг эрэлхийлсэн ч гэсэн, болгоогтун, бид илднүүдээ зайлуулан нуух болно, тийм ээ, бүр тэдгээр нь эцсийн өдөр, бид тэдгээрийг хэзээ ч хэрэглээгүйн гэрчлэл болж өнгөлөг хэвээрээ хадгалагдаж болохын тулд газрын гүнд тэдгээрийг булшлах болно; мөн хэрэв ах дүүс маань биднийг устгах аваас, болгоогтун, бид Бурхандаа очиж мөн аврагдах болно.

17 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор хаан эдгээр үгийг төгсгөж, мөн бүх хүмүүс цугларахад, тэд илднүүдээ, мөн хүмүүний цус урсгахын тулд хэрэглэгдэж байсан бүх зэр зэвсгээ авч, мөн тэдгээрийг газрын гүнд булшлав.

18 Мөн үүнийг хийсэн нь тэд хэзээ ч хүмүүний цусыг урсгахаар зэр зэвсэг дахин хэрэглэхгүй хэмээн Бурханд мөн түүнчлэн хүмүүнд хандсан тэдний гэрчлэл мөн гэж тэд үзсэн ажээ; мөн тэд үүнийг хийж, мөн ах дүүсийнхээ цусыг урсгахын оронд тэд амиа алдацгаах болно гэдгээ тэд Бурханд батламжлан мөн гэрээлсэн бөлгөө; мөн ах дүүгээ авснаас түүний оронд тэд өгөх болно хэмээв; мөн өөрсдийн өдрүүдээ залхаг байдалд өнгөрөөсөнд орвол өөрсдийн гараар ихэд хөдөлмөрлөх болно хэмээв.

19 Мөн тийн бид, эдгээр леменчүүд итгэхэд мөн үнэнийг мэдэхэд авчрагдаж, тэд тууштай байж, мөн нүгэл үйлдэхийн оронд бүр үхлийг хүртэл зовоход бэлэн байсныг харлаа; мөн тийн тэд энх амгалангийн зэр зэвсгээ, өөрөөр хэлбэл тэд дайны зэр зэвсгээ энх амгалангийн төлөө булшилсныг бид харлаа.

Oh, how merciful is our God! And now behold, since it has been as much as we could do to get our stains taken away from us, and our swords are made bright, let us hide them away that they may be kept bright, as a testimony to our God at the last day, or at the day that we shall be brought to stand before him to be judged, that we have not stained our swords in the blood of our brethren since he imparted his word unto us and has made us clean thereby.

And now, my brethren, if our brethren seek to destroy us, behold, we will hide away our swords, yea, even we will bury them deep in the earth, that they may be kept bright, as a testimony that we have never used them, at the last day; and if our brethren destroy us, behold, we shall go to our God and shall be saved.

And now it came to pass that when the king had made an end of these sayings, and all the people were assembled together, they took their swords, and all the weapons which were used for the shedding of man's blood, and they did bury them up deep in the earth.

And this they did, it being in their view a testimony to God, and also to men, that they never would use weapons again for the shedding of man's blood; and this they did, vouching and covenanting with God, that rather than shed the blood of their brethren they would give up their own lives; and rather than take away from a brother they would give unto him; and rather than spend their days in idleness they would labor abundantly with their hands.

And thus we see that, when these Lamanites were brought to believe and to know the truth, they were firm, and would suffer even unto death rather than commit sin; and thus we see that they buried their weapons of peace, or they buried the weapons of war, for peace.

- 20 Мөнхүү улиран тохиох дор тэдний ах дүүс, леменчүүд, дайнд зориулан бэлтгэлүүдийг хийж, мөн хааныг устгах мөн түүний оронд өөрийг тавих, мөн түүнчлэн Антай-Нифай-Лихайн хүмүүсийг уг нутгаас гарган устгах зорилгоор Нифайн нутагт иржээ.
- 21 Эдүгээ хүмүүс өөрсдийнх нь эсрэг тэдний ирж буйг хараад тэдэнтэй уулзахаар тэд гарцгаав, мөн тэдний өмнө өөрсдийгөө газарт сунан хэвтэхэд хүргэж мөн Их Эзэний нэрийг дуудаж эхлэв; мөн тийн леменчүүд тэдний зүг дайран, мөн тэднийг илдээрээ алж эхлэхэд тэд ийм байдалтай байв.
- 22 Мөн тийн ямар ч эсэргүүцэлгүйгээр, тэдний нэгэн мянга тавыг нь алсан болой; мөн тэд адислагдсаныг бид мэднэ, учир нь тэд Бурхантайгаа оршихоор одсон билээ.
- 23 Эдүгээ леменчүүд өөрсдийнх нь ах дүүс илднээс зугтахгүй, бас баруун эсвэл зүүн гар тийш эргэхгүй байгааг, харин тэд хэвтэж мөн эрсдэж, мөн Бурханыг, бүр илдэн дор эрсдэх яг тэр үедээ ч магтаж буйг хараад—
- 24 Эдүгээ леменчүүд үүнийг хараад тэд тэднийг алахаа болив; мөн тэднээс олных нь зүрх сэтгэл илдэн дор унасан ах дүүсийнхээ төлөө гэгэлзэн байв, учир нь тэд хийсэн зүйлүүдийнхээ улмаас наманчилсан ажгуу.
- 25 Мөнхүү улиран тохиох дор тэд дайны зэвсгээ, мөн тэд тэдгээрийг дахин авмааргүйгээр доош хаяв, учир нь тэд өөрсдийн үйлдсэн аллагуудын улмаас зовиурлаж байв; мөн бүр тэднийг алахаар гараа далайсан өөрсдийнх нь нигүүлсэлд хандсан өөрсдийн ах дүүс мэт тэд доош сөхрөв.
- 26 Мөнхүү улиран тохиох дор тэр өдөр алагдсанаас Бурханы илүү олон хүмүүс нэгтгэгдэв; мөн алагдсан тэд зөв шударга хүмүүс байв, тиймийн тул тэднийг аврагдсанд эргэлзэх ямар ч шалтгаан бидэнд үгүй болой.
- 27 Мөн ёс бус хүн тэдний дунд алагдсангүй; харин мянгаас илүү олон нь үнэний мэдлэгт авчрагдав; тийн бид Их Эзэн өөрийн хүмүүсийн авралын төлөө олон аргаар ажиллагдийг харлаа.

And it came to pass that their brethren, the Lamanites, made preparations for war, and came up to the land of Nephi for the purpose of destroying the king, and to place another in his stead, and also of destroying the people of Anti-Nephi-Lehi out of the land.

Now when the people saw that they were coming against them they went out to meet them, and prostrated themselves before them to the earth, and began to call on the name of the Lord; and thus they were in this attitude when the Lamanites began to fall upon them, and began to slay them with the sword.

And thus without meeting any resistance, they did slay a thousand and five of them; and we know that they are blessed, for they have gone to dwell with their God.

Now when the Lamanites saw that their brethren would not flee from the sword, neither would they turn aside to the right hand or to the left, but that they would lie down and perish, and praised God even in the very act of perishing under the sword—

Now when the Lamanites saw this they did forbear from slaying them; and there were many whose hearts had swollen in them for those of their brethren who had fallen under the sword, for they repented of the things which they had done.

And it came to pass that they threw down their weapons of war, and they would not take them again, for they were stung for the murders which they had committed; and they came down even as their brethren, relying upon the mercies of those whose arms were lifted to slay them.

And it came to pass that the people of God were joined that day by more than the number who had been slain; and those who had been slain were righteous people, therefore we have no reason to doubt but what they were saved.

And there was not a wicked man slain among them; but there were more than a thousand brought to the knowledge of the truth; thus we see that the Lord worketh in many ways to the salvation of his people.

28 Эдүгээ ах дүүсээсээ олныг алсан тэдгээр леменчүүдээс хамгийн олон тоотой нь амалекайчууд болон амюлончууд байв, тэдний ихэнх нь нихорчуудын жаягийн дагуух хүмүүс байв.

29 Эдүгээ, Их Эзэний хүмүүст нэгдсэн тэдний дунд, амалекайчууд эсвэл амюлончууд, эсвээс Нихорын жаягийнхнаас нэг ч байсангүй, харин тэд Лемен болон Лемүелийн жинхэнэ үр удам байв.

30 Мөн тийн аливаа хүмүүс нэгэнт Бурханы Сүнсээр гэгээрүүлэгдсэний дараа, мөн зөв шударгад хамаарах зүйлсийн агуу мэдлэгтэй байсны дараа, мөн тэгээд нүгэл болон зөрчилд унасан бол, тэд илүү хатуурч, мөн тийн тэдний байдал хэрэв тэд эдгээр зүйлийг хэзээ ч мэдээгүй байснаас дор болдгийг бид тодорхойгоор олж харж чадна.

Now the greatest number of those of the Lamanites who slew so many of their brethren were Amalekites and Amulonites, the greatest number of whom were after the order of the Nehors.

Now, among those who joined the people of the Lord, there were none who were Amalekites or Amulonites, or who were of the order of Nehor, but they were actual descendants of Laman and Lemuel.

And thus we can plainly discern, that after a people have been once enlightened by the Spirit of God, and have had great knowledge of things pertaining to righteousness, and then have fallen away into sin and transgression, they become more hardened, and thus their state becomes worse than though they had never known these things.

## Алма 25

- 1 Мөнхүү болгоогтун, эдүгээ улиран тохиох дор тэдгээр леменчүүд ах дүүсээ алсан учир илүү их ууртай байв; тиймийн тул тэд нифайчуудаас өс хонзон авахаар тангараглав; мөн тэд тэр цагт Антай-Нифай-Лихайн хүмүүсийг алахаар дахин завдахаа болив.
- 2 Харин тэд их цэргээ авч мөн Зарахемла нутгийн хилийг давж, мөн Аммонайха нутагт байсан хүмүүсийг довтлон мөн тэднийг устгав.
- 3 Мөн түүний дараа, тэд өөрсдөө туугдаж мөн алагдсан олон тулааныг нифайчуудтай хийв.
- 4 Мөн алагдсан леменчүүдийн дунд Ноагийн санваартнууд болох Амюлоны мөн тэдний ах дүүсийнх нь бараг бүх үр удам байв, мөн тэд нифайчуудын гараар алагдсан байв;
- 5 Мөн үлдэгдэл нь, дорнын аглаг буйд тийш зугтаж, мөн тэд леменчүүдийн дээрх хүч мөн эрх мэдлийг хууль бусаар булаан эзэлсэн учир, леменчүүдээс олон нь итгэлийнхээ учир галд эрсдэхэд хүргэгдэв—
- 6 Учир нь тэднээс олон нь их алдагдал хийгээд маш олон зовлонг хүлцсэний дараа, Аарон болон түүний ах дүүс тэдэнд өөрсдийнх нь нутагт номлосон үгсийн санамжинд өдөөгдөж эхлэв; тиймийн тул тэд эцэг өвгөдийнхөө уламжлалуудад итгэл алдарч, мөн Их Эзэнд, мөн тэрээр нифайчуудад агуу хүчийг өгсөн гэдэгт итгэж эхлэв; мөн тийн аглаг буйдад тэднээс олон нь хөрвүүлэгдэв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Амюлоны хүүхдүүдийн үлдэгдэл асан тэдгээр захирагчид тэднийг, тийм ээ, эдгээр зүйлд итгэсэн тэд бүгдийг үхэлд хүргэв.
- 8 Эдүгээ энэ аллага тэдний ах дүүсээс олныг уур хилэнд өдөөн хатгагдах болгов; мөн аглаг буйдад зөрчилдөөн болж эхлэв; мөн леменчүүд Амюлоны мөн түүний ах дүүсийн үр удмыг ангуучилж эхлэн мөн тэднийг хөнөөж эхлэв; мөн тэд дорнын аглаг буйд тийш зугтав.
- 9 Мөн болгоогтун тэд энэ өдөр ч леменчүүдээр ангуучлагдсаар байв. Галд эрсдэх түүний үхлийг амсах болгосон санваартнуудын үр удмын талаар хэлсэн Абинадайн үгс тийн улиран тохиосон болой.

## Alma 25

And behold, now it came to pass that those Lamanites were more angry because they had slain their brethren; therefore they swore vengeance upon the Nephites; and they did no more attempt to slay the people of Anti-Nephi-Lehi at that time.

But they took their armies and went over into the borders of the land of Zarahemla, and fell upon the people who were in the land of Ammonihah and destroyed them.

And after that, they had many battles with the Nephites, in the which they were driven and slain.

And among the Lamanites who were slain were almost all the seed of Amulon and his brethren, who were the priests of Noah, and they were slain by the hands of the Nephites;

And the remainder, having fled into the east wilderness, and having usurped the power and authority over the Lamanites, caused that many of the Lamanites should perish by fire because of their belief—

For many of them, after having suffered much loss and so many afflictions, began to be stirred up in remembrance of the words which Aaron and his brethren had preached to them in their land; therefore they began to disbelieve the traditions of their fathers, and to believe in the Lord, and that he gave great power unto the Nephites; and thus there were many of them converted in the wilderness.

And it came to pass that those rulers who were the remnant of the children of Amulon caused that they should be put to death, yea, all those that believed in these things.

Now this martyrdom caused that many of their brethren should be stirred up to anger; and there began to be contention in the wilderness; and the Lamanites began to hunt the seed of Amulon and his brethren and began to slay them; and they fled into the east wilderness.

And behold they are hunted at this day by the Lamanites. Thus the words of Abinadi were brought to pass, which he said concerning the seed of the priests who caused that he should suffer death by fire.

10 Учир нь тэрээр тэдэнд хэлэв: Та нар надад юу хийх нь ирэх зүйлүүдийн хэв шинж байх болно.

11 Мөн эдүгээ Абинадай Бурханд итгэх итгэлийнхээ учир галд эрсдэх үхлийг үзсэн эхнийх нь байв; эдүгээ энэ нь түүний хэлсэн, түүний амссаны дагуу галаар эрсдэх үхлийг олон хүн амсах болно гэсэн утгатай ажээ.

12 Мөн тэрээр Ноагийн санваартнуудад ийн хэлжээ, тэдний үр удам олныг түүний нэгэн адил маягаар үхэлд хүргэх болно, мөн тэд тараагдаж мөн алагдаж, бүр хоньчингүй хонь мэт туугдаж мөн зэрлэг араатнуудаар алагдах лугаа адил буюу; мөн эдүгээ болгоогтун, эдгээр үг нотлогдсон билээ, учир нь тэд леменчүүдээр туугдаж, мөн тэд ангуучлагдсан, мөн тэд цохигдсон бөлгөө.

13 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд нифайчуудыг захиран дийлж эс чадахаа үзээд нутагтаа дахин эргэж ирсэн; мөн тэдний олон нь Ишмэилийн нутагт мөн Нифайн нутагт оршихоор ирж, мөн өөрсдийгөө Антай-Нифай-Лихайн хүмүүс болох, Бурханы хүмүүстэй нэгтгэв.

14 Мөн тэд ах дүүсийнхээ хийсний дагуу, дайны зэр зэвсгүүдээ түүнчлэн булшилж, мөн тэд зөв шударга хүмүүс болж эхлэв; мөн тэд Их Эзэний замаар алхалж, мөн түүний зарлигуудыг хийгээд түүний дүрмүүдийг дагахаар эрмэлзсэн билээ.

15 Тийм ээ, мөн тэд Мосегийн хуулийг дагадаг байв; учир нь тэд тухайн үед бүгд гүйцэлдээгүй байсан учраас Мосегийн хуулийг дагах нь зайлшгүй байв. Харин Мосегийн хууль байсан хэдий ч, Мосегийн хууль нь түүний ирэлтийн хэв шинж байсан хэмээн бодож, мөн тэрээр тэдэнд илчлэгдэх тэр цагийг хүртэл гадна талын ёслолуудыг дагах ёстой гэдэгт итгэсэн учир тэд Христийн ирэлтийг харуулдан хүлээж байв.

16 Эдүгээ тэд Мосегийн хуулиар аврал ирнэ гэж бодсонгүй; харин Мосегийн хууль нь Христэд итгэх тэдний итгэлийг хүчирхэгжүүлэхэд үйлчилдэг байв; мөн ирэх тэдгээр зүйлүүдийн тухай ярьсан бошиглолын суу билэг дээр тэд тулгуурлан, мөн тийн тэд мөнхийн авралд хүргэх найдварыг хадгалдаг байв.

For he said unto them: What ye shall do unto me shall be a type of things to come.

And now Abinadi was the first that suffered death by fire because of his belief in God; now this is what he meant, that many should suffer death by fire, according as he had suffered.

And he said unto the priests of Noah that their seed should cause many to be put to death, in the like manner as he was, and that they should be scattered abroad and slain, even as a sheep having no shepherd is driven and slain by wild beasts; and now behold, these words were verified, for they were driven by the Lamanites, and they were hunted, and they were smitten.

And it came to pass that when the Lamanites saw that they could not overpower the Nephites they returned again to their own land; and many of them came over to dwell in the land of Ishmael and the land of Nephi, and did join themselves to the people of God, who were the people of Anti-Nephi-Lehi.

And they did also bury their weapons of war, according as their brethren had, and they began to be a righteous people; and they did walk in the ways of the Lord, and did observe to keep his commandments and his statutes.

Yea, and they did keep the law of Moses; for it was expedient that they should keep the law of Moses as yet, for it was not all fulfilled. But notwithstanding the law of Moses, they did look forward to the coming of Christ, considering that the law of Moses was a type of his coming, and believing that they must keep those outward performances until the time that he should be revealed unto them.

Now they did not suppose that salvation came by the law of Moses; but the law of Moses did serve to strengthen their faith in Christ; and thus they did retain a hope through faith, unto eternal salvation, relying upon the spirit of prophecy, which spake of those things to come.

17 Мөн эдүгээ болгоогтун, Аммон, мөн Аарон, мөн Омнер, мөн Химнай, мөн тэдний ах дүүс үлэмж баяссаны учир нь Их Эзэн өөрсдийнх нь залбирлуудын дагуу тэдэнд өгсөн леменчүүдийн дундах тэдний амжилт, мөн түүнчлэн тэрээр өөрийн үгсийг тэдэнд зүйл бүр дээр нь нотолсных бөлгөө.

And now behold, Ammon, and Aaron, and Omner, and Himni, and their brethren did rejoice exceedingly, for the success which they had had among the Lamanites, seeing that the Lord had granted unto them according to their prayers, and that he had also verified his word unto them in every particular.



## Алма 26

- 1 Мөн эдүгээ, эдгээр нь ах дүүсдээ хандсан Аммоны үгс болой, ийн хэлэв: Ах дүүс минь мөн нөхөд минь, болгоогтун би та нарт хэлнэ, бидэнд баясаж болох ямар агуу шалтгаан байнав; учир нь бид Зарахемла нутгаас эхлэхдээ Бурхан бидэнд ийм их адислалуудыг өгөх болно гэдгийг бодож чадаж байсан гэж үү
- 2 Мөн эдүгээ, би асууна, бидний дээр ямар агуу адислалуудыг тэр соёрхсон билээ? Та нар хэлж чадах уу
- 3 Болгоогтун, би та нарт хариулна; тухайлбал бидний ах дүүс, леменчүүд, харанхуйд, тийм ээ, бүр хамгийн харанхуй ангалд байсан, гэвч болгоогтун, тэднээс хичнээн олон нь Бурханы гайхамшигт гэрлийг болгоохоор авчрагдсан билээ! Мөн бид энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд Бурханы мутар дахь зэмсгүүд болгогдсон нь, бидний дээр бэлэглэгдсэн адислал болой.
- 4 Болгоогтун, тэдний мянга мянга нь баясна, мөн Бурханы сүрэгт авчрагдсан болой.
- 5 Болгоогтун, талбай боловсорч гүйцсэн байв, мөн адислагдсан болой та нар, учир нь та нар хадуураа барьж, мөн чадлаараа хадсан, тийм ээ, бүхэл өдрийн турш та нар хөдөлмөрлөсөн; мөн боодлуудынхаа тоог болгоогтун! Мөн тэдгээр нь үрэгдэхгүйн тулд тариа хадгалах газруудад хураагдах болно.
- 6 Тийм ээ, тэд эцсийн өдөр шуурганд цохигдохгүй; тийм ээ, тэдгээр нь салхин хүрдэнд ч автагдахгүй; харин шуурга ирэхэд, шуурга тэднийг нэвтэлж чадахгүйн тул тэдгээр нь байрандаа нэгдэн цуглуулагдах болно; тийм ээ, бас тэд дайсны хүссэн хаана боловч тэдгээрийг аваачих догшин салхинд туугдахгүй бөлгөө.
- 7 Гэвч болгоогтун, тэд ургацын Их Эзэний мутарт байна, мөн тэд түүнийх билээ; мөн тэрээр эцсийн өдөр тэднийг босгох болно.
- 8 Бурханы минь нэр алдаршиг; түүнийг магтахад дуугаа өргөцгөөе, тийм ээ, түүний ариун нэрэнд талархал өргөө, учир нь тэр зөв шударгын ажлыг үүрд үйлддэг билээ.

## Alma 26

And now, these are the words of Ammon to his brethren, which say thus: My brothers and my brethren, behold I say unto you, how great reason have we to rejoice; for could we have supposed when we started from the land of Zarahemla that God would have granted unto us such great blessings?

And now, I ask, what great blessings has he bestowed upon us? Can ye tell?

Behold, I answer for you; for our brethren, the Lamanites, were in darkness, yea, even in the darkest abyss, but behold, how many of them are brought to behold the marvelous light of God! And this is the blessing which hath been bestowed upon us, that we have been made instruments in the hands of God to bring about this great work.

Behold, thousands of them do rejoice, and have been brought into the fold of God.

Behold, the field was ripe, and blessed are ye, for ye did thrust in the sickle, and did reap with your might, yea, all the day long did ye labor; and behold the number of your sheaves! And they shall be gathered into the garners, that they are not wasted.

Yea, they shall not be beaten down by the storm at the last day; yea, neither shall they be harrowed up by the whirlwinds; but when the storm cometh they shall be gathered together in their place, that the storm cannot penetrate to them; yea, neither shall they be driven with fierce winds whithersoever the enemy listeth to carry them.

But behold, they are in the hands of the Lord of the harvest, and they are his; and he will raise them up at the last day.

Blessed be the name of our God; let us sing to his praise, yea, let us give thanks to his holy name, for he doth work righteousness forever.

- 9 Тухайлбал хэрэв бид Зарахемла нутгаас ирээгүй бол, биднийг ийм эрхмээр хайрласан, эдгээр эрхэм хайрт ах дүүс маань бидний эсрэг үзэн ядалтандаа тарчилсаар байх байсан, тийм ээ, мөн тэд түүнчлэн Бурханы хувьд танихгүй хүмүүс байх сан билээ.
- 10 Мөнхүү улиран тохиох дор Аммон эдгээр үгсийг хэлэхэд, түүний ах Аарон түүнийг зэмлэн, хэлэв: Аммон, баясал чинь чамайг бардамнан сагсуурахад хүргэлээ хэмээн би айх юм.
- 11 Гэвч Аммон түүнд хэлрүүн: Би өөрийн хүч чадалд, бас өөрийн мэргэн ухаанд ч бардамнан сагсуураагүй байна; гэвч болгоогтун, миний баясал дүүрч, тийм ээ, зүрх сэтгэл минь баяслаар халгинам, мөн би Бурхандаа баярлах болно.
- 12 Тийм ээ, би юу ч биш гэдгээ мэднэ; чадлынхаа хувьд би сул дорой; тиймийн тул би өөрөөрөө бардамнахгүй, харин би Бурханаараа бардамнах болно, учир нь түүний хүч чадалд би бүх зүйлийг хийж чадна; тийм ээ, болгоогтун, олон хүчит гайхамшигийг бид энэ нутагт гүйцээсэн, үүнийхээ учир би түүний нэрийг үүрд алдаршуулах болно.
- 13 Болгоогтун, тэрээр хичнээн мянган ах дүүсийг минь тамын шаналлаас сулласан билээ; мөн тэд гэтэлгэлийн хайрыг дуулахад хүргэгддэг, мөн энэ нь бидэнд байдаг түүний үгийн хүчний учир юм, тиймийн тул баясах агуу шалтгаан бидэнд байхгүй гэж үү
- 14 Тийм ээ, бидэнд түүнийг үүрд алдаршуулах шалтгаан буй, учир нь тэр бол Бүхний Дээд Бурхан, мөн ах дүүсийг маань тамын гинжнээс сулласан болой.
- 15 Тийм ээ, тэд үүрдийн харанхуй мөн устгалаар хүрээлэгдсэн байлаа; гэвч болгоогтун, тэрээр өөрийн үүрдийн гэрэлд, тийм ээ, үүрдийн авралд тэднийг авчирсан; мөн тэд түүний зүйрлэшгүй өгөөмөр хайраар хүрээлэгдсэн билээ; тийм ээ, мөн бид энэ агуу хийгээд гайхамшигт ажлыг хийхэд түүний мутар дахь зэмсгүүд байсан билээ.

For if we had not come up out of the land of Zarahemla, these our dearly beloved brethren, who have so dearly beloved us, would still have been racked with hatred against us, yea, and they would also have been strangers to God.

And it came to pass that when Ammon had said these words, his brother Aaron rebuked him, saying: Ammon, I fear that thy joy doth carry thee away unto boasting.

But Ammon said unto him: I do not boast in my own strength, nor in my own wisdom; but behold, my joy is full, yea, my heart is brim with joy, and I will rejoice in my God.

Yea, I know that I am nothing; as to my strength I am weak; therefore I will not boast of myself, but I will boast of my God, for in his strength I can do all things; yea, behold, many mighty miracles we have wrought in this land, for which we will praise his name forever.

Behold, how many thousands of our brethren has he loosed from the pains of hell; and they are brought to sing redeeming love, and this because of the power of his word which is in us, therefore have we not great reason to rejoice?

Yea, we have reason to praise him forever, for he is the Most High God, and has loosed our brethren from the chains of hell.

Yea, they were encircled about with everlasting darkness and destruction; but behold, he has brought them into his everlasting light, yea, into everlasting salvation; and they are encircled about with the matchless bounty of his love; yea, and we have been instruments in his hands of doing this great and marvelous work.

16 Тиймийн тул, бахархацгаая, тийм ээ, бид Их Эзэнээр бахархах болно; тийм ээ, бид баясах болно, учир нь бидний баясал дүүрэн байна; тийм ээ, бид Бурханаа үүрд магтан дуулах болно. Болгоогтун, хэн Их Эзэнд хэтэрхий их алдрыг өргөж чадах билээ? Тийм ээ, түүний агуу их хүчний тухай, мөн түүний нигүүлслийн тухай, мөн хүмүүний үрсэд хандах түүний гэсвэрийн тухай хэн хэтэрхий ихийг хэлж чадах билээ? Болгоогтун, би та нарт хэлнэ, би өөрийн мэдэрч байгаагийнхаа хамгийн бага хэсгийг ч хэлж чадахгүй.

17 Бурхан маань биднийг өөрсдийн маань аймшигт, нүгэлт мөн бузартсан байдлаас шүүрч авахаар тийм нигүүлсэнгүй хэмээн хэн бодох билээ

18 Болгоогтун, бид бүр уур хилэгнэлтэйгээр, түүний сүмийг устгах гэсэн хүчит заналхийлэлтэйгээр урагшлан явсан билээ.

19 Ай тэгээд, яагаад тэрээр биднийг аймшигт устгалд оногдуулсангүй вэ, тийм ээ, яагаад тэрээр өөрийн шударга ёсны илдийг бидний дээр буулгасангүй вэ, мөн биднийг мөнхийн цөхрөлд ялласангүй вэ

20 Ай, сүнс минь, бараг л ингэж бодохоос зайлсхиймээр байна. Болгоогтун, тэрээр өөрийн шударга ёсыг бидний дээр эс хэрэгжүүлэн, харин агуу их нигүүлсэлдээ биднийг тэр үүрдийн үхлийн мөн аймшигийн ангалаас хэлтрүүлж, бүр бидний сүнсний авралд авчирсан билээ.

21 Мөн эдүгээ болгоогтун, ах дүүс минь, эдгээр зүйлийг мэддэг ямар эгэл хүн байдаг билээ? Би та нарт хэлнэ, нүглээ наманчлагч байхаас бусдаар, эдгээр зүйлийг мэддэг нэгээхэн ч үгүй бөлгөө.

22 Тийм ээ, наманчилдаг мөн итгэлээ бодитой болгодог, мөн сайн үйлүүдийг авчирдаг, мөн үргэлж тасралтгүйгээр залбирдаг түүнд—ийм нэгэнд Бурханы нууцууд мэдэгдэхээр өгөгдсөн байдаг; тийм ээ, хэзээ ч илчлэгдэж байгаагүй зүйлүүд илчлэгдэхээр ийм нэгэнд өгөгдөх болно; тийм ээ, мөн мянга мянган бодгалийг наманчлалд авчрах нь, бүр өөрсдийн эдгээр ах дүүсийг наманчлалд авчрах нь бидэнд өгөгдсөний адилаар ийм нэгэнд өгөгдөх болно.

Therefore, let us glory, yea, we will glory in the Lord; yea, we will rejoice, for our joy is full; yea, we will praise our God forever. Behold, who can glory too much in the Lord? Yea, who can say too much of his great power, and of his mercy, and of his long-suffering towards the children of men? Behold, I say unto you, I cannot say the smallest part which I feel.

Who could have supposed that our God would have been so merciful as to have snatched us from our awful, sinful, and polluted state?

Behold, we went forth even in wrath, with mighty threatenings to destroy his church.

Oh then, why did he not consign us to an awful destruction, yea, why did he not let the sword of his justice fall upon us, and doom us to eternal despair?

Oh, my soul, almost as it were, fleeth at the thought. Behold, he did not exercise his justice upon us, but in his great mercy hath brought us over that everlasting gulf of death and misery, even to the salvation of our souls.

And now behold, my brethren, what natural man is there that knoweth these things? I say unto you, there is none that knoweth these things, save it be the penitent.

Yea, he that repenteth and exerciseth faith, and bringeth forth good works, and prayeth continually without ceasing—unto such it is given to know the mysteries of God; yea, unto such it shall be given to reveal things which never have been revealed; yea, and it shall be given unto such to bring thousands of souls to repentance, even as it has been given unto us to bring these our brethren to repentance.

23 Эдүгээ ах дүүс минь, бид Зарахемла нутагт ах дүүс-тээ, бид Нифайн нутагт ах дүүс леменчүүддээ номлохоор очихыг хэлэхэд, мөн тэд биднийг элэглэн дооглож инээлдсэнийг та нар санаж байна уу

24 Учир нь тэд бидэнд хэлэв: Та нар леменчүүдийг үнэний мэдлэгт авчирч чадна хэмээн бодно уу? Та нар цус урсгахдаа зүрх нь баясах тэднийг; өдрүүд нь хамгийн бузар алдсуудад өнгөрсөн тэднийг; зам нь эхлэлээс л зөрчигчийн зам байсан тэднийг, тэр чигээрээ зөрүүд хүмүүс, леменчүүдэд эцэг өвгөдийнх нь заншил зөв бус гэдэгт тэднийг үнэмшүүлэн ухааруулж чадна хэмээн бодно уу? Эдүгээ ах дүүс минь, энэ нь тэдний үгс байсныг та нар санаж байгаа.

25 Мөн үүнээс гадна тэд хэлэв: Тэдний эсрэг зэвсэглэцгээе, тэд биднийг дийлж мөн биднийг устгахгүйн тулд бид тэднийг мөн тэдний алдсуудыг уг нутгаас устгах болно.

26 Гэвч болгоогтун, хайрт ах дүүс минь, бид аглаг буйдад ах дүүсээ устгах зорилготойгоор бус харин тэдний бодгалиудаас цөөн хэдийг боловч аварч болох магад хэмээх зорилготойгоор ирсэн билээ.

27 Эдүгээ бидний зүрх шантарч, мөн бараг л буцах гэж байхад, болгоогтун, Их Эзэн биднийг тайтгаруулан, мөн хэлэв: Өөрсдийн ах дүүс, леменчүүдийн дунд явагтун, мөн зовлонгуудаа тэвчээртэйгээр туул, мөн би та нарт амжилтыг өгөх болно гэсэн бөлгөө.

28 Мөн эдүгээ болгоогтун, бид ирж, мөн тэдний дунд орсон; мөн бид зовлонгууддаа тэвчээртэй байв, мөн бид гачигдал бүрийг туулсан бөлгөө; тийм ээ, дэлхийн нигүүлсэл дээр—зөвхөн дэлхийн нигүүлсэл дээр ч бус харин түүнчлэн Бурханы нигүүлсэл дээр тулгуурлан бид байшингаас байшин хүртэл аялсан.

29 Мөн бид тэдний гэрт орж мөн тэдэнд зааж, мөн тэдэнд гудамжинд нь сургаж байв; тийм ээ; мөн бид толгод дээр тэдэнд зааж байв; мөн түүнчлэн бид тэдний ариун сүмүүдэд мөн тэдний синагогуудад орж мөн тэдэнд заасан; мөн бид хөөгдөж, мөн элэглэгдэж, мөн нулимуулж, мөн хацар дээрээ цохиулж байлаа; мөн бид чулуугаар шидүүлж, мөн баривчлагдаж мөн бөх олсоор хүлэгдэж, шоронд хаягдаж байв; мөн Бурханы хүч мөн мэргэн ухаанаар бид дахин чөлөөлөгдөж байсан болой.

Now do ye remember, my brethren, that we said unto our brethren in the land of Zarahemla, we go up to the land of Nephi, to preach unto our brethren, the Lamanites, and they laughed us to scorn?

For they said unto us: Do ye suppose that ye can bring the Lamanites to the knowledge of the truth? Do ye suppose that ye can convince the Lamanites of the incorrectness of the traditions of their fathers, as stiff-necked a people as they are; whose hearts delight in the shedding of blood; whose days have been spent in the grossest iniquity; whose ways have been the ways of a transgressor from the beginning? Now my brethren, ye remember that this was their language.

And moreover they did say: Let us take up arms against them, that we destroy them and their iniquity out of the land, lest they overrun us and destroy us.

But behold, my beloved brethren, we came into the wilderness not with the intent to destroy our brethren, but with the intent that perhaps we might save some few of their souls.

Now when our hearts were depressed, and we were about to turn back, behold, the Lord comforted us, and said: Go amongst thy brethren, the Lamanites, and bear with patience thine afflictions, and I will give unto you success.

And now behold, we have come, and been forth amongst them; and we have been patient in our sufferings, and we have suffered every privation; yea, we have traveled from house to house, relying upon the mercies of the world—not upon the mercies of the world alone but upon the mercies of God.

And we have entered into their houses and taught them, and we have taught them in their streets; yea, and we have taught them upon their hills; and we have also entered into their temples and their synagogues and taught them; and we have been cast out, and mocked, and spit upon, and smote upon our cheeks; and we have been stoned, and taken and bound with strong cords, and cast into prison; and through the power and wisdom of God we have been delivered again.

- 30 Мөн бид бүх л төрлийн зовлонгуудыг, мөн энэ бүгдийг, бид зарим нэг бодгалийг аврах хэрэгсэл байж болох магад хэмээн туулсан билээ; мөн хэрэв бид магад зарим хэдийг аврах хэрэгсэл байж чадвал бидний баясал дүүрэн байна хэмээн бодсон буюу.
- 31 Эдүгээ болгоогтун, бид урагш харж мөн хөдөлмөрийнхөө үр жимсийг харж чадна; мөн тэдгээр нь цөөхөн гэж үү? Би та нарт хэлнэ, Үгүй, тэдгээр нь олон; тийм ээ, мөн бид тэдний чинхүү сэтгэлийг харж чадна, ах дүүстээ хандсан, мөн түүнчлэн бидэнд хандсан тэдний хайрын учир болой.
- 32 Учир нь болгоогтун, тэд бүр дайсныхаа амийг авснаас өөрсдийн амийг золиосолсон нь дээр хэмээсэн болой; мөн тэд дайны зэр зэвсгүүдээ газрын гүнд булшилсан, ах дүүстээ хандсан тэдний хайрын учир болой.
- 33 Мөн эдүгээ болгоогтун би та нарт хэлнэ, бүх нутагт ийм агуу их хайр байсан уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй, байгаагүй, бүр нифайчуудын дунд ч гэсэн тэр.
- 34 Учир нь болгоогтун, тэд ах дүүсийнхээ эсрэг зэвсгээ агсахад бэлэн байсан; тэд өөрсдийгөө алуулахыг тэвчээгүй. Гэвч болгоогтун тэдний хичнээн олон нь амиа өгсөн билээ; мөн өөрсдийн хайр мөн нүгэлд хандах хонзогнолынхоо учир тэд өөрсдийн Бурханд одсоныг бид мэднэ.
- 35 Эдүгээ бидэнд баясах шалтгаан үгүй гэж үү? Тийм ээ, би та нарт хэлнэ, дэлхий эхэлснээс хойш бидний адил ийм агуу баясах шалтгаантай хүмүүн хэзээ ч байгаагүй; тийм ээ, мөн баясал минь бүр Бурханаараа бардамнах бардамналд хүргэв; учир нь түүнд бүх хүч чадал, бүх мэргэн ухаан, мөн бүх ойлголт байдаг; тэрээр бүх зүйлийг ухаардаг мөн наманчлах мөн түүний нэрэнд итгэдэг тэднийг бүр авралд хүргэх тэрээр нигүүлсэнгүй Нэгэн бөлгөө.
- 36 Эдүгээ хэрэв энэ нь бардамнал аваас, тэрчлэн би бардамнах болно; учир нь энэ бол миний амьдрал мөн миний гэрэл, миний баясал бөгөөд миний аврал, мөн үүрдийн халгаас гэтэлгэх миний гэтэлгэл. Тийм ээ, мөн харь нутагт биеэсээ гээгдсэн Израилын модны мөчир болох энэ хүмүүст анхааран хандсан Бурханы минь нэр алдаршсан болой; тийм ээ, би хэлнэ, Бурханы минь, харь газар бэдрэх биднийг анхаарч үзсэн, түүний нэр алдаршиг.

And we have suffered all manner of afflictions, and all this, that perhaps we might be the means of saving some soul; and we supposed that our joy would be full if perhaps we could be the means of saving some.

Now behold, we can look forth and see the fruits of our labors; and are they few? I say unto you, Nay, they are many; yea, and we can witness of their sincerity, because of their love towards their brethren and also towards us.

For behold, they had rather sacrifice their lives than even to take the life of their enemy; and they have buried their weapons of war deep in the earth, because of their love towards their brethren.

And now behold I say unto you, has there been so great love in all the land? Behold, I say unto you, Nay, there has not, even among the Nephites.

For behold, they would take up arms against their brethren; they would not suffer themselves to be slain. But behold how many of these have laid down their lives; and we know that they have gone to their God, because of their love and of their hatred to sin.

Now have we not reason to rejoice? Yea, I say unto you, there never were men that had so great reason to rejoice as we, since the world began; yea, and my joy is carried away, even unto boasting in my God; for he has all power, all wisdom, and all understanding; he comprehendeth all things, and he is a merciful Being, even unto salvation, to those who will repent and believe on his name.

Now if this is boasting, even so will I boast; for this is my life and my light, my joy and my salvation, and my redemption from everlasting wo. Yea, blessed is the name of my God, who has been mindful of this people, who are a branch of the tree of Israel, and has been lost from its body in a strange land; yea, I say, blessed be the name of my God, who has been mindful of us, wanderers in a strange land.

37 Эдүгээ ах дүүс минь, тэд аль ч нутагт байсан хүмүүс болгоныг Бурхан анхааран үздэгийг бид харлаа; тийм ээ, тэрээр өөрийн хүмүүсийг тоолж, мөн нигүүлслийнх нь зүрх сэтгэл бүх дэлхийг бүрхдэг билээ. Эдүгээ энэ нь миний баясал, мөн миний агуу талархал; тийм ээ, мөн Бурхандаа би үүрд талархах болно. Амен.

Now my brethren, we see that God is mindful of every people, whatsoever land they may be in; yea, he numbereth his people, and his bowels of mercy are over all the earth. Now this is my joy, and my great thanksgiving; yea, and I will give thanks unto my God forever. Amen.

## Алма 27

- 1 Эдүгээ улиран тохиох дор нифайчуудын эсрэг дайтахаар явсан леменчүүд, тэднийг устгах гэсэн олон оролдлогынхоо дараа тэднийг устгахыг эрэлхийлэх нь дэмий болохыг олж мэдээд, тэд Нифайн нутагт дахин эргэж очив.
- 2 Мөнхүү улиран тохиох дор амалекайчууд, гарз хохирлынхоо учир, үлэмж ууртай байв. Мөн тэд нифайчуудаас өшөө авч чадаагүйгээ үзээд, тэд өөрсдийнх нь ах дүүс болох Антай-Нифай-Лихайн хүмүүсийн эсрэг уур хилэнд хүмүүсийг өдөөн хатгаж эхлэв; тиймийн тул тэд дахин тэднийг устгаж эхлэв.
- 3 Эдүгээ энэ хүмүүс зэвсгээ агсахаас дахин татгалзаж мөн дайснуудынхаа хүслийн дагуу өөрсдийгөө алуулахыг тэд хүлцэв.
- 4 Эдүгээ Аммон мөн түүний ах дүүс, өөрсдийнх нь тэгж дотноор хайрласан, мөн өөрсдийг нь тэгж дотноор хайрласан—учир нь тэд бол Бурханаас тэднийг үүрдийн устгалаас аврахаар илгээгдсэн тэнгэр элчүүд лугаа адил тэдэнд хандаж байв—тэдний дундах устгалын энэхүү ажлыг хараад, тиймийн тул, Аммон болон тэдний ах дүүс устгалын агуу ажлыг хараад тэд өрөвдөн догдолж, мөн тэд хаанд хэлэв:
- 5 Их Эзэний энэ хүмүүсийг нэгтгэн цуглуулцгаая, мөн Зарахемлагийн нутаг дахь бидний ахан дүүс нифайчууд уруу явж, мөн бид устгагдахгүйн тул дайснуудынхаа гараас зугтан гарцгаая.
- 6 Гэвч хаан тэдэнд хэлэв: Болгоогтун, тэдний эсрэг бидний үйлдсэн олон аллага мөн нүглүүдийн учир нифайчууд биднийг устгах болно.
- 7 Мөн Аммон хэлэв: Би явж мөн Их Эзэнээс лавлах болно, мөн хэрэв тэр биднийг ах дүүсдээ оч хэмээвэл, та нар явах уу
- 8 Мөн хаан түүнд хэлэв: Тийм ээ, хэрэв Их Эзэн бидэнд явахыг хэлбэл, бид ах дүүс уруугаа явах болно, мөн тэдний эсрэг өөрсдийн үйлдсэн олон аллага хийгээд нүглүүдээ тэдэнд залруулах хүртлээ бид тэдний боол байх болно.
- 9 Гэвч Аммон түүнд хэлэв: Энэ бол ах дүүсийн маань, тэдний дунд нэг ч боол байх ёсгүй гэсэн миний эцгээр тогтоогдсон хуулийн эсрэг болой; тиймийн тул тийш явцгааж мөн ах дүүсийнхээ нигүүлсэл дээр түшиглэе.

## Alma 27

Now it came to pass that when those Lamanites who had gone to war against the Nephites had found, after their many struggles to destroy them, that it was in vain to seek their destruction, they returned again to the land of Nephi.

And it came to pass that the Amalekites, because of their loss, were exceedingly angry. And when they saw that they could not seek revenge from the Nephites, they began to stir up the people in anger against their brethren, the people of Anti-Nephi-Lehi; therefore they began again to destroy them.

Now this people again refused to take their arms, and they suffered themselves to be slain according to the desires of their enemies.

Now when Ammon and his brethren saw this work of destruction among those whom they so dearly beloved, and among those who had so dearly beloved them—for they were treated as though they were angels sent from God to save them from everlasting destruction—therefore, when Ammon and his brethren saw this great work of destruction, they were moved with compassion, and they said unto the king:

Let us gather together this people of the Lord, and let us go down to the land of Zarahemla to our brethren the Nephites, and flee out of the hands of our enemies, that we be not destroyed.

But the king said unto them: Behold, the Nephites will destroy us, because of the many murders and sins we have committed against them.

And Ammon said: I will go and inquire of the Lord, and if he say unto us, go down unto our brethren, will ye go?

And the king said unto him: Yea, if the Lord saith unto us go, we will go down unto our brethren, and we will be their slaves until we repair unto them the many murders and sins which we have committed against them.

But Ammon said unto him: It is against the law of our brethren, which was established by my father, that there should be any slaves among them; therefore let us go down and rely upon the mercies of our brethren.

10 Гэвч хаан түүнд хэлэв: Их Эзэнээс лавла, мөн хэрэв тэр бидэнд явахыг хэлбэл, бид явах болно; өөрөөр бол бид нутагтаа мөхөх болно.

11 Мөнхүү улиран тохиох дор Аммон одож мөн Их Эзэнээс лавлав, мөн Их Эзэн түүнд хэлэв:

12 Тэд мөхөхгүйн тулд энэ хүмүүсийг авч энэ нутгаас гарга; учир нь ах дүүсийнх нь эсрэг уурлуулж мөн тэднийг алуулахаар леменчүүдийг өдөөн хатгаж буй амалекайчуудын зүрхэнд Сатан агуу байр эзэлжээ; тиймийн тул та энэ нутгаас гарч яв; мөн энэ хүмүүс энэ үедээ адислагдсан билээ, учир нь би тэднийг хадгалан хамгаалах болно.

13 Мөн эдүгээ улиран тохиох дор Аммон явж мөн хаанд Их Эзэн түүнд хэлсэн тэр бүхий л үгсийг хэлэв.

14 Мөн тэд өөрсдийн бүх хүмүүсийг нэгтгэн цуглуулж, тийм ээ, Их Эзэний бүх хүмүүсийг, мөн тэдний бүх бог болон бод малыг нэгтгэн цуглуулж, мөн уг нутгаас гарч, мөн Нифайн нутгийг Зарахемлагийн нутгаас зааглан хуваадаг аглаг буйдад ирж, мөн нутгийн хилийн ойролцоо ирэв.

15 Мөнхүү улиран тохиох дор Аммон тэдэнд хэлэв: Болгоогтун, би түүнчлэн миний ах дүүс Зарахемлагийн нутаг тийш явах болно, мөн та нар биднийг эргэж иртэл эндээ үлдэх болно; мөн бид ах дүүсийнхээ сэтгэлийг сонжин тэд та нарыг нутагтаа оруулахыг хүсэх эсэхийг мэдэх болно.

16 Мөнхүү улиран тохиох дор Аммон уг нутагт орж явахдаа, өмнө нь дурдагдсан тэрхүү газарт тэр болон түүний ах дүүс Алматай тааралдав; мөн болгоогтун, энэ нь баярт уулзалт байв.

17 Эдүгээ Аммоны баясал нь, бүр тэрбээр дүүрэн байсан тийм агуу байв; тийм ээ, тэрбээр бүр хүч нь тамирдах хүртэл Бурхандаа баясах баясалд халгилж байв; мөн тэр дахин газар уналаа.

18 Эдүгээ энэ нь үлэмжийн баясал байсан бус уу? Болгоогтун, энэ нь үнэнээр гэмшигчээс хийгээд баяр баясгаланг даруухнаар эрэлхийлэгчээс өөр хэн ч хүлээн авахгүй тэр баясал болой.

But the king said unto him: Inquire of the Lord, and if he saith unto us go, we will go; otherwise we will perish in the land.

And it came to pass that Ammon went and inquired of the Lord, and the Lord said unto him:

Get this people out of this land, that they perish not; for Satan has great hold on the hearts of the Amalekites, who do stir up the Lamanites to anger against their brethren to slay them; therefore get thee out of this land; and blessed are this people in this generation, for I will preserve them.

And now it came to pass that Ammon went and told the king all the words which the Lord had said unto him.

And they gathered together all their people, yea, all the people of the Lord, and did gather together all their flocks and herds, and departed out of the land, and came into the wilderness which divided the land of Nephi from the land of Zarahemla, and came over near the borders of the land.

And it came to pass that Ammon said unto them: Behold, I and my brethren will go forth into the land of Zarahemla, and ye shall remain here until we return; and we will try the hearts of our brethren, whether they will that ye shall come into their land.

And it came to pass that as Ammon was going forth into the land, that he and his brethren met Alma, over in the place of which has been spoken; and behold, this was a joyful meeting.

Now the joy of Ammon was so great even that he was full; yea, he was swallowed up in the joy of his God, even to the exhausting of his strength; and he fell again to the earth.

Now was not this exceeding joy? Behold, this is joy which none receiveth save it be the truly penitent and humble seeker of happiness.



19 Эдүгээ Алмагийн ах дүүстэйгээ уулзсан баясал, мөн түүнчлэн Аароны, Омнерийн мөн Химнайн баясал үнэхээр агуу их байв; гэвч болгоогтун тэдний баясал тэдний хүчийг тамирдуулахаар тийм байсангүй.

20 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма ах дүүсээ Зарахемлагийн нутаг тийш; бүр өөрийнхөө гэрийг хүртэл буцаан удирдав. Мөн тэд явж мөн, Нифайн нутагт, өөрсдийн ах дүүс леменчүүдийн дунд тэдэнд юу тохиолдсон бүх зүйлийг ерөнхий шүүгчид хэлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор Антай-Нифай-Лихайн хүмүүс асан ах дүүсээ оруулах талаар хүмүүсийн саналыг ерөнхий шүүгч хүсэн бүх нутаг даяар зар илгээв.

22 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал ирэв, өгүүлсэн нь: Болгоогтун, бид дорнодод тэнгисийн тэнд байдаг, Өгөөмөр нутагтай хиллэдэг, Өгөөмөр нутгийн өмнөдөд байдаг Жершоны нутгийг өгөх болно; мөн бидний ах дүүсдээ өв залгамжлуулан өгөх нутаг нь Жершоны нутаг болой.

23 Мөн болгоогтун, бид Жершоны нутагт ах дүүсээ хамгаалж болохын тулд бид их цэргээ Жершоны нутаг болон Нифайн нутгийн хооронд байрлуулах болно; мөн ах дүүсийнхээ эсрэг зэвсэг агсаж нүгэл үйлдэхээс эмээх айдсын улмаас ах дүүсийнхээ төлөө бид үүнийг хийнэ; мөн энэ агуу айдас нь тэдний олон аллага мөн тэдний аймшигт ёс бус явдлын улмаас, үйлдсэн тэрхүү шаналалт наманчлалын улмаас ирсэн болой.

24 Мөн эдүгээ болгоогтун, тэд Жершоны нутгийг өвлөж болохын тулд бид ах дүүсдээ үүнийг хийх болно; мөн бидэнд, бид их цэрэгтээ дэмжлэг үзүүлж болохын тулд тэд бидэнд туслан хөрөнгөнийхөө хэсгээс өгөх нөхцөлд бид тэднийг дайснуудаас нь их цэргээрээ хамгаалах болно.

25 Эдүгээ, улиран тохиох дор Аммон үүнийг сонсоод, тэр Антай-Нифай-Лихайн хүмүүст, мөн түүнчлэн Алма түүнтэй хамт, аглаг буйд тийш тэдний майхнуудаа босгосон газар эргэж очиж, мөн тэдэнд эдгээр бүх зүйлийг мэдүүлэв. Мөн Алма түүнчлэн өөрийн Аммон, Аарон хоёр, бас түүний ах дүүстэй хамт хөрвүүлэгдсэнээ тэдэнд өгүүлэв.

Now the joy of Alma in meeting his brethren was truly great, and also the joy of Aaron, of Omner, and Himni; but behold their joy was not that to exceed their strength.

And now it came to pass that Alma conducted his brethren back to the land of Zarahemla; even to his own house. And they went and told the chief judge all the things that had happened unto them in the land of Nephi, among their brethren, the Lamanites.

And it came to pass that the chief judge sent a proclamation throughout all the land, desiring the voice of the people concerning the admitting their brethren, who were the people of Anti-Nephi-Lehi.

And it came to pass that the voice of the people came, saying: Behold, we will give up the land of Jershon, which is on the east by the sea, which joins the land Bountiful, which is on the south of the land Bountiful; and this land Jershon is the land which we will give unto our brethren for an inheritance.

And behold, we will set our armies between the land Jershon and the land Nephi, that we may protect our brethren in the land Jershon; and this we do for our brethren, on account of their fear to take up arms against their brethren lest they should commit sin; and this their great fear came because of their sore repentance which they had, on account of their many murders and their awful wickedness.

And now behold, this will we do unto our brethren, that they may inherit the land Jershon; and we will guard them from their enemies with our armies, on condition that they will give us a portion of their substance to assist us that we may maintain our armies.

Now, it came to pass that when Ammon had heard this, he returned to the people of Anti-Nephi-Lehi, and also Alma with him, into the wilderness, where they had pitched their tents, and made known unto them all these things. And Alma also related unto them his conversion, with Ammon and Aaron, and his brethren.

- 26 Мөнхүү улиран тохиох дор энэ нь тэдний дунд агуу баясал авчрав. Мөн тэд Жершоны нутагт уруудан очиж, мөн Жершоны нутгийг эзэмшилдээ авав; мөн тэд нифайчуудаар Аммоны хүмүүс гэж нэрлэгдэв; тиймийн тул тэд уг нэрээр цаашид ялгарах болов.
- 27 Мөн тэд Нифайн хүмүүсийн дунд байж, мөн түүнчлэн Бурханы сүмд байсан хүмүүсийн дунд тоологдов. Мөн тэд түүнчлэн Бурханд хандсан, мөн түүнчлэн хүмүүст хандсан өөрсдийн хичээл зүтгэлээр онцгойлогдсон байв; учир нь тэд бүх зүйлд төгс шударга мөн зөв шулуун байв; мөн тэд Христэд итгэх итгэлдээ бүр эцсээ хүртэл гуйвшгүй байв.
- 28 Мөн тэд ах дүүсийнхээ цус урсгахыг хамгийн их жигшил зэвүүцэлтэйгээр хардаг байв; мөн тэд хэзээ ч ах дүүсийнхээ эсрэг зэвсэг агсахаар ятгагдаж байсангүй; мөн тэд үхлийг ямар нэгэн аймшиг хэмээн бодохоо больжээ, Христийн тухай болон амилуулалтын тухай найдвар ойлголтын учир болой; тиймийн тул, тэдний хувьд үхэл нь, үүнийг давсан Христийн ялалтаар үгүйсгэгдсэн билээ.
- 29 Тиймийн тул, тэднийг цохихоор илдээ эсвэл сэлмээ тэд барихаасаа өмнө тэд өөрсдийн ах дүүсээр учруулагдаж болох хамгийн гамшигт хийгээд зүдгүүрт үхлийг тэвчихэд бэлэн байв.
- 30 Мөн тийн тэд хичээнгүй мөн хайрлагдсан хүмүүс, Их Эзэн ихээр таалсан хүмүүс байв.

And it came to pass that it did cause great joy among them. And they went down into the land of Jershon, and took possession of the land of Jershon; and they were called by the Nephites the people of Ammon; therefore they were distinguished by that name ever after.

And they were among the people of Nephi, and also numbered among the people who were of the church of God. And they were also distinguished for their zeal towards God, and also towards men; for they were perfectly honest and upright in all things; and they were firm in the faith of Christ, even unto the end.

And they did look upon shedding the blood of their brethren with the greatest abhorrence; and they never could be prevailed upon to take up arms against their brethren; and they never did look upon death with any degree of terror, for their hope and views of Christ and the resurrection; therefore, death was swallowed up to them by the victory of Christ over it.

Therefore, they would suffer death in the most aggravating and distressing manner which could be inflicted by their brethren, before they would take the sword or cimeter to smite them.

And thus they were a zealous and beloved people, a highly favored people of the Lord.

## Алма 28

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Аммоны хүмүүс Жершоны нутагт суурьшсаны, мөн түүнчлэн Жершоны нутагт сүм байгуулагдсаны, мөн нифайчуудын их цэрэг Жершоны нутгийн эргэн тойронд тийм ээ, Зарахемлагийн нутгийн бүх хилийг хүрээлэн байрлуулагдсаны дараа; болгоогтун леменчүүдийн их цэрэг ах дүүсээ аглаг буйдад мөрдсөн ажээ.
- 2 Мөн тийн аймшигт тулаан болов; тийм ээ, бүр Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас уг нутагт бүх хүмүүний дунд хэзээ ч мэдэгдэж байгаагүй тийм тулалдаан болов; тийм ээ, мөн леменчүүдийн хэдэн арван мянга нь алагдан мөн тараан сарниулагдав.
- 3 Тийм ээ, мөн түүнчлэн Нифайн хүмүүсийн дунд ч аймшигт аллага болов; гэсэн хэдий ч, леменчүүд туугдан мөн сарниулагдаж, мөн Нифайн хүмүүс нутагтаа эргэж ирэв.
- 4 Мөн эдүгээ энэ нь бүх нутаг даяар Нифайн бүх хүмүүсийн дунд агуу гашуудал болон харуусал сонсогдсон нэгэн үе байв—
- 5 Тийм ээ, бэлэвсэн эхнэрүүд нөхрүүдийнхээ төлөө, мөн түүнчлэн эцгүүд хөвгүүдийнхээ төлөө, мөн охид ах нарынхаа төлөө, тийм ээ, хөвгүүд нь эцгүүдийнхээ төлөө гашуудан уйлж байв; мөн тийн алагдсан төрлүүдийнхээ төлөө гашуудах нь, тэд бүгдийн дунд гашуудан уйлах нь сонсогдож байв.
- 6 Мөн эдүгээ энэ нь гунигтай өдөр байсан нь гарцаагүй; тийм ээ, гашуудлын үе, мөн их мацаг барилт хийгээд залбирлын үе болой.
- 7 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арвантав дахь он төгсөв;
- 8 Мөн энэ нь Аммон болон түүний ах дүүсийн, Нифайн нутаг дахь тэдний аялал, уг нутаг дахь тэдний зовлон, тэдний харуусал, мөн тэдний зүдрэлүүдийн, мөн тэдний ухааршгүй их баяслын, мөн Жершоны нутаг дахь ах дүүсийнх нь хүлээн авалт мөн аюулгүй байдлын шастир болой. Мөн эдүгээ бүх хүмүүний Гэтэлгэгч Их Эзэн тэдний бодгалиудыг үүрд адислах болтугай.
- 9 Мөн энэ нь нифайчуудын дундах дайн ууд хийгээд тэмцлүүдийн, мөн түүнчлэн нифайчууд болон леменчүүдийн хоорондох дайнуудын шастир болой; мөн шүүгчдийн засаглалын арвантав дахь он төгсөв.

## Alma 28

And now it came to pass that after the people of Ammon were established in the land of Jershon, and a church also established in the land of Jershon, and the armies of the Nephites were set round about the land of Jershon, yea, in all the borders round about the land of Zarahemla; behold the armies of the Lamanites had followed their brethren into the wilderness.

And thus there was a tremendous battle; yea, even such an one as never had been known among all the people in the land from the time Lehi left Jerusalem; yea, and tens of thousands of the Lamanites were slain and scattered abroad.

Yea, and also there was a tremendous slaughter among the people of Nephi; nevertheless, the Lamanites were driven and scattered, and the people of Nephi returned again to their land.

And now this was a time that there was a great mourning and lamentation heard throughout all the land, among all the people of Nephi—

Yea, the cry of widows mourning for their husbands, and also of fathers mourning for their sons, and the daughter for the brother, yea, the brother for the father; and thus the cry of mourning was heard among all of them, mourning for their kindred who had been slain.

And now surely this was a sorrowful day; yea, a time of solemnity, and a time of much fasting and prayer.

And thus endeth the fifteenth year of the reign of the judges over the people of Nephi;

And this is the account of Ammon and his brethren, their journeyings in the land of Nephi, their sufferings in the land, their sorrows, and their afflictions, and their incomprehensible joy, and the reception and safety of the brethren in the land of Jershon. And now may the Lord, the Redeemer of all men, bless their souls forever.

And this is the account of the wars and contentions among the Nephites, and also the wars between the Nephites and the Lamanites; and the fifteenth year of the reign of the judges is ended.

10 Мөн анхны оноос арван тав дахийг хүртэлх хугацаанд олон мянган амь эрсдэлт улиран тохиожээ; тийм ээ, үүнд нь аймшигт цус урсалтын үзэгдэл улиран тохиожээ.

11 Мөн олон мянган цогцос газрын гадаргуу дээр овоорон ялзарч байхад олон мянган цогцос газар дор тавигдаж; тийм ээ, мөн олон мянга нь төрөл төрөгсдөө алдсандаа гашуудаж байв, учир нь Их Эзэний амлалтуудын дагуу, тэд төгсгөлгүй гаслангийн байдалд тохоогджээ хэмээн айх шалтгаан тэдэнд буй.

12 Өөр олон мянга нь төрөл төрөгсдөө алдсандаа үнэхээр гашуудан байх зуураа, гэсэн ч тэд Бурханы баруун гар талд оршихоор, хэзээ ч төгсөхгүй аз жаргалын байдалд босгогдсоныг Их Эзэний амлалтуудын дагуу тэд найдвартаа баясан мөн хөөрч, мөн бүр мэдэж байв.

13 Мөн тийн хүмүүний зүрх сэтгэлийг урхидахаар зохиосон түүний зальт төлөвлөгөөнүүдээр ирэх тэр нүгэл болон зөрчлийн, мөн чөтгөрийн хүчний учир хүмүүний тэгш бус байдал ямар агуут бид харлаа.

14 Мөн тийн Их Эзэний талбайнуудад хөдөлмөрлүүлэхээр хүмүүнийг шаргуу байдалд дуудах агуу дуудлагыг бид харлаа; мөн тийн харууслын хийгээд түүнчлэн баяслын хүмүүний дундах үхэл хийгээд устгалаас үүдэх харууслыг, түүнчлэн амьдралд хүргэх Христийн гэрлээс үүдэх баяслыг агуу шалтгааныг—бид харлаа.

And from the first year to the fifteenth has brought to pass the destruction of many thousand lives; yea, it has brought to pass an awful scene of bloodshed.

And the bodies of many thousands are laid low in the earth, while the bodies of many thousands are moldering in heaps upon the face of the earth; yea, and many thousands are mourning for the loss of their kindred, because they have reason to fear, according to the promises of the Lord, that they are consigned to a state of endless wo.

While many thousands of others truly mourn for the loss of their kindred, yet they rejoice and exult in the hope, and even know, according to the promises of the Lord, that they are raised to dwell at the right hand of God, in a state of never-ending happiness.

And thus we see how great the inequality of man is because of sin and transgression, and the power of the devil, which comes by the cunning plans which he hath devised to ensnare the hearts of men.

And thus we see the great call of diligence of men to labor in the vineyards of the Lord; and thus we see the great reason of sorrow, and also of rejoicing—sorrow because of death and destruction among men, and joy because of the light of Christ unto life.

## Алма 29

- 1 Ай би тэнгэр элч болж, зүрхний минь хүсэл гүйцэлдэх болоосой, тиймээс би явж мөн Бурханы бүрэн дуугаар, газар дэлхийг сэгсрэх дуу хоолойгоор ярьж мөн хүмүүс болгонд наманчлалыг зарлаж болдог ч болоосой!
- 2 Тийм ээ, наманчлалыг мөн гэтэлгэлийн төлөвлөгөөг, газар дэлхийн бүхий л гадаргуу дээр дахин харамсал үгүй байж болохын тулд тэд наманчилж мөн Бурханд ирэхийг бодгаль болгонд аянгын дуун мэт зарлах сан би.
- 3 Гэвч болгоогтун, би бол хүн, мөн энэ хүсэлдээ нүглийг үйлдлээ; учир нь Их Эзэн надад тохоосон зүйлүүдэд хангалуун байвал зохино би.
- 4 Шударга Бурханы чанд тогтоолыг би өөрийн хүслээр гуйвуулах ёсгүй, учир нь тэрээр тэдний хүслийн дагуу, тэр нь үхэлд эсвэл амьдралд хүргэх байлаа ч түүнийг нь хүмүүнд зөвшөөрдгийг мэднэ би, тийм ээ, тэдний тааллуудын дагуу, тэд авралд эсвээс устгалд хүргэх байлаа ч тэрээр хүмүүнд түүнийг нь оногдуулдаг, тийм ээ, өөрчлөгдөшгүй тэр тогтоолуудыг тэдэнд тохоодог.
- 5 Тийм ээ, мөн бүх хүмүүний өмнө сайн болон муу ирсэн байдгийг би мэднэ; муугаас сайныг ялгаж мэддэггүй тэр нь гэм зэмгүй; харин сайн хийгээд мууг мэддэг тэр, тэрээр сайн эсвээс мууг, амьдралыг эсвээс үхлийг, баяслыг эсвээс ухамсрын гэмшлийг алийг нь ч хүслээ гэсэн түүний хүслийн дагуу тэр нь түүнд өгөгддөг бөлгөө.
- 6 Эдүгээ, би эдгээр зүйлийг мэддэг атал, өөрийнхөө дуудагдсан тэр ажлыг гүйцэтгэхээс илүүг би яагаад хүсэх болов
- 7 Би тэнгэр элч байхыг, тиймээс дэлхийн бүх хязгаарт ч би ярьж чаддаг байхыг яагаад хүсэх болов, би
- 8 Учир нь болгоогтун, Их Эзэн бүх үндэстнүүдэд, өөрийн үгийг, тийм ээ, мэргэн ухаанаар, өөрийнхөө болно хэмээн үзсэн бүгдийг заах заримыг тэдний өөрсдийнх нь үндэстэн хийгээд хэлтнээс өгдөг болой; тиймийн тул Их Эзэн мэргэн ухаанд, шударга ёс хийгээд үнэний дагуу зөвлөдгийг бид харлаа.

## Alma 29

O that I were an angel, and could have the wish of mine heart, that I might go forth and speak with the trump of God, with a voice to shake the earth, and cry repentance unto every people!

Yea, I would declare unto every soul, as with the voice of thunder, repentance and the plan of redemption, that they should repent and come unto our God, that there might not be more sorrow upon all the face of the earth.

But behold, I am a man, and do sin in my wish; for I ought to be content with the things which the Lord hath allotted unto me.

I ought not to harrow up in my desires the firm decree of a just God, for I know that he granteth unto men according to their desire, whether it be unto death or unto life; yea, I know that he allotteth unto men, yea, decreeth unto them decrees which are unalterable, according to their wills, whether they be unto salvation or unto destruction.

Yea, and I know that good and evil have come before all men; he that knoweth not good from evil is blameless; but he that knoweth good and evil, to him it is given according to his desires, whether he desireth good or evil, life or death, joy or remorse of conscience.

Now, seeing that I know these things, why should I desire more than to perform the work to which I have been called?

Why should I desire that I were an angel, that I could speak unto all the ends of the earth?

For behold, the Lord doth grant unto all nations, of their own nation and tongue, to teach his word, yea, in wisdom, all that he seeth fit that they should have; therefore we see that the Lord doth counsel in wisdom, according to that which is just and true.

- 9 Их Эзэний надад зарлигласныг би мэднэ, мөн үүгээр бахархана би. Би өөрөөрөө бахархахгүй, харин Их Эзэн надад зарлигласан түүгээр бахархана би; тийм ээ, мөн энэ нь, зарим бодгалиудыг наманчлалд авчрахад Бурханы мутар дахь зэмсэг байж болох нь миний бахархал; мөн энэ нь миний баясал.
- 10 Мөн болгоогтун, ах дүүсийн маань олон нь үнэхээр гэмшихийг, мөн Их Эзэн Бурхандаа ирэхийг харахад, бодгаль минь баяслаар дүүрнэм; тэгээд Их Эзэн миний төлөө юу хийснийг санадаг би, тийм ээ, бүр тэрээр залбирлыг минь сонссоныг; тийм ээ, тэгээд миний зүг сунгасан түүний нигүүлсэнгүй мутрыг санадаг болой би.
- 11 Тийм ээ, мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө боолчлогдож байсныг би санадаг; учир нь Их Эзэн тэднийг боолчлолоос чөлөөлж, мөн тэгснээр өөрийн сүмийг байгуулсныг лавтай мэддэг болой би; тийм ээ, Их Эзэн Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурхан тэднийг боолчлолоос чөлөөлсөн билээ.
- 12 Тийм ээ, эцэг өвгөдийнхөө боолчлогдсоныг үргэлж санасаар байдаг би; мөн тэднийг египетчүүдийн гараас чөлөөлсөн тэрхүү Бурхан тэднийг боолчлолоос чөлөөлсөн билээ.
- 13 Тийм ээ, мөнхүү тэр Бурхан тэдний дунд өөрийн сүмийг байгуулсан билээ; тийм ээ, мөнхүү тэр Бурхан намайг, энэ хүмүүст үгийг номлох ариун дуудлагаар дуудсан юм, мөн тэрэндээ баясал минь дүүрэх их амжилтыг надад өгсөн билээ.
- 14 Гэвч би зөвхөн өөрийн амжилтанд баясах бус, харин Нифайн нутагт байсан ах дүүсийнхээ амжилтын төлөө баясал минь илүү дүүрэн байна.
- 15 Болгоогтун, тэд үлэмж их хөдөлмөрлөсөн, мөн их үр шимийг авчирсан; мөн шагнал нь хичнээн агуу байх билээ!
- 16 Эдүгээ, эдгээр ах дүүсийнхээ амжилтын тухай намайг бодоход сүнс минь зөөгдөн одож, бүр биеэс салах лугаа адил, баясал минь тийм агуу байна.

I know that which the Lord hath commanded me, and I glory in it. I do not glory of myself, but I glory in that which the Lord hath commanded me; yea, and this is my glory, that perhaps I may be an instrument in the hands of God to bring some soul to repentance; and this is my joy.

And behold, when I see many of my brethren truly penitent, and coming to the Lord their God, then is my soul filled with joy; then do I remember what the Lord has done for me, yea, even that he hath heard my prayer; yea, then do I remember his merciful arm which he extended towards me.

Yea, and I also remember the captivity of my fathers; for I surely do know that the Lord did deliver them out of bondage, and by this did establish his church; yea, the Lord God, the God of Abraham, the God of Isaac, and the God of Jacob, did deliver them out of bondage.

Yea, I have always remembered the captivity of my fathers; and that same God who delivered them out of the hands of the Egyptians did deliver them out of bondage.

Yea, and that same God did establish his church among them; yea, and that same God hath called me by a holy calling, to preach the word unto this people, and hath given me much success, in the which my joy is full.

But I do not joy in my own success alone, but my joy is more full because of the success of my brethren, who have been up to the land of Nephi.

Behold, they have labored exceedingly, and have brought forth much fruit; and how great shall be their reward!

Now, when I think of the success of these my brethren my soul is carried away, even to the separation of it from the body, as it were, so great is my joy.

17 Мөн эдүгээ эдэнд, ах дүүст маань, тэд Бурханы хаант улсад сууж болно хэмээн Бурхан соёрхох болтугай; тийм ээ, мөн түүнчлэн тэдний хөдөлмөрийн үр шим болох тэдгээр нь бүгд дахин хэзээ ч алга болохгүй, харин түүнийг үүрд магтах болтугай. Мөн энэ нь миний үгсийн дагуу бүр ярьсны минь адилаар байхыг Бурхан соёрхох болтугай. Амен.

And now may God grant unto these, my brethren, that they may sit down in the kingdom of God; yea, and also all those who are the fruit of their labors that they may go no more out, but that they may praise him forever. And may God grant that it may be done according to my words, even as I have spoken. Amen.

## Алма 30

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Аммоны хүмүүс Жершоны нутагт суурьшуулагдсаны дараа, тийм ээ, мөн түүнчлэн леменчүүд уг нутгаас туугдсаны, мөн тэдний үхэгсэд нутгийн хүмүүсээр оршуулагдсаны дараа—
- 2 Эдүгээ тэдний үхэгсэд тоологдоогүйн учир нь тооны нь агуу ихээс болой; бас нифайчуудын үхэгсэд нь ч тоологдсонгүй—гэвч улиран тохиох дор тэд үхэгсдээ оршуулсны дараа, мөн түүнчлэн мацаг барилт мөн гашуудал, мөн залбирлын өдрүүдийн дараа (энэ нь Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван зургадугаар он байв) бүх нутаг даяар үргэлжийн амгалан эхлэв.
- 3 Тийм ээ, мөн хүмүүс Их Эзэний зарлигуудыг дагахаар мэрийцгээсэн болой; мөн тэд Мосегийн хуулийн дагуу Бурханы ёслолуудыг гүйцэтгэхдээ чанд байв; учир нь тэд биелэгдэх хүртэл нь Мосегийн хуулийг сахихаар сургагдав.
- 4 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван зургадугаар оны турш хүмүүст ямар ч үймээн үгүй байв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын арван долдугаар оны эхлэлд үргэлжийн амгалан байв.
- 6 Гэвч улиран тохиох дор арван долдугаар оны төгсгөлд, Зарахемлагийн нутагт нэгэн хүн ирэв, мөн тэр нь Христийг эсэргүүцэгч байв, учир нь тэрээр Христийн ирэлтийн талаар бошиглогчдоор яригдсан бошиглолуудын эсрэг хүмүүст номлож эхлэв.
- 7 Эдүгээ хүмүүний сүсэг бишрэлийн эсрэг хууль байсангүй; учир нь хүмүүсийг тэгш бус байдалд хүргэх хууль нь Бурханы зарлигуудын хувьд туйлын эсрэг байсны улмаас болой.
- 8 Учир нь сударт ийн өгүүлдэг: Та нар энэ өдөр хэнд үйлчлэхээ сонго.
- 9 Эдүгээ хэрэв хүмүүн Бурханд үйлчлэхийг хүсвэл, энэ нь түүний эрх байв; эсвээс, хэрэв тэр Бурханд итгэдэг бол түүнд үйлчлэх нь түүний эрх байв; харин итгэдэггүй бол түүнийг шийтгэх хууль үгүй байв.

## Alma 30

Behold, now it came to pass that after the people of Ammon were established in the land of Jershon, yea, and also after the Lamanites were driven out of the land, and their dead were buried by the people of the land—

Now their dead were not numbered because of the greatness of their numbers; neither were the dead of the Nephites numbered—but it came to pass after they had buried their dead, and also after the days of fasting, and mourning, and prayer, (and it was in the sixteenth year of the reign of the judges over the people of Nephi) there began to be continual peace throughout all the land.

Yea, and the people did observe to keep the commandments of the Lord; and they were strict in observing the ordinances of God, according to the law of Moses; for they were taught to keep the law of Moses until it should be fulfilled.

And thus the people did have no disturbance in all the sixteenth year of the reign of the judges over the people of Nephi.

And it came to pass that in the commencement of the seventeenth year of the reign of the judges, there was continual peace.

But it came to pass in the latter end of the seventeenth year, there came a man into the land of Zarahemla, and he was Anti-Christ, for he began to preach unto the people against the prophecies which had been spoken by the prophets, concerning the coming of Christ.

Now there was no law against a man's belief; for it was strictly contrary to the commands of God that there should be a law which should bring men on to unequal grounds.

For thus saith the scripture: Choose ye this day, whom ye will serve.

Now if a man desired to serve God, it was his privilege; or rather, if he believed in God it was his privilege to serve him; but if he did not believe in him there was no law to punish him.



10 Харин хэрэв тэр аллага үйлдвэл тэрээр үхлээр шийтгэгддэг байв; мөн хэрэв тэрээр дээрэмдсэн бол түүнчлэн шийтгэгддэг байв; мөн хэрэв тэр хулгайлсан бол тэрээр түүнчлэн шийтгэгддэг байв; мөн хэрэв тэр садар самууныг үйлдсэн бол тэрээр түүнчлэн шийтгэгддэг байв; тийм ээ, энэ бүх ёс бусын төлөө тэд шийтгэгддэг байв.

11 Учир нь хүмүүс гэмт хэргүүдийнхээ дагуу шүүгдэх ёстой хэмээх нэгэн хууль байв. Гэсэн хэдий ч, хүмүүний сүсэг бишрэлийн эсрэг хууль байсангүй; тиймийн тул, хүмүүн нь зөвхөн үйлдсэн гэмт хэргүүдийнхээ улмаас шийтгэгддэг байв; тиймийн тул бүх хүмүүн тэгш эрхтэй байв.

12 Мөн энэхүү Христийг эсэргүүцэгч, нэр нь Корихор гэгч тэр, (мөн хууль нь түүнд хүрч чадахгүй байв) Христ байх нь үгүй хэмээн хүмүүст номлож эхлэв. Мөн ийм маягаар тэр номлож, хэлрүүн:

13 Хоосон бөгөөд мунхаг найдвартаа хүлэгдсэн та нар, яагаад та нар өөрсдийгөө ийм мунхаг зүйлүүдээр буулгалдаг билээ? Яагаад та нар ямар нэгэн Христийг хүлээнэв? Учир нь нэг ч хүн ирэх түүний тухай юуг ч мэдэж чадахгүй.

14 Болгоогтун, та нарын бошиглолууд гэж нэрлэдэг эдгээр зүйлүүд, та нарын ариун бошиглогчдоор дамжуулагдсан гэж хэлдэг тэр нь, болгоогтун, тэдгээр нь эцэг өвгөдийн чинь мунхаг уламжлалууд болой.

15 Тэдгээрийн гарцаагүйг та нар яаж мэддэг вэ? Болгоогтун, та нар харахгүй байгаа тэр зүйлийг мэдэж чадахгүй; тиймийн тул та нар хэн нэгэн Христ байх болно гэдгийг мэдэж чадахгүй.

16 Та нар урагш хараад мөн та нар нүглүүдийнхээ ангижралыг үздэг хэмээн хэлдэг. Гэвч болгоогтун, энэ бол галзуурсан сэтгэлийн нөлөө; мөн та нарын энэ сэтгэцийн гажиг та нарыг тийм бус тэр зүйлүүдийн итгэлд хөтөлсөн эцэг өвгөдийн чинь уламжлалуудаас болдог.

17 Мөн тэрээр иймэрхүү олон зүйлийг тэдэнд хэлэв, хүмүүний нүглүүдийн төлөө цагаатгал хийгдэх боломжгүй, харин хүн бүр энэ амьдралд биеийг удирдахын дагуу аж төрдөг; тиймийн тул хүн бүр өөрийн суу билгийн дагуу дэгжиж, мөн хүн бүр өөрийн хүчний дагуу ялан дийлдэг; мөн хүмүүний хийсэн юу боловч гэмт хэрэг бус хэмээн тэдэнд өгүүлэв.

But if he murdered he was punished unto death; and if he robbed he was also punished; and if he stole he was also punished; and if he committed adultery he was also punished; yea, for all this wickedness they were punished.

For there was a law that men should be judged according to their crimes. Nevertheless, there was no law against a man's belief; therefore, a man was punished only for the crimes which he had done; therefore all men were on equal grounds.

And this Anti-Christ, whose name was Korihor, (and the law could have no hold upon him) began to preach unto the people that there should be no Christ. And after this manner did he preach, saying:

O ye that are bound down under a foolish and a vain hope, why do ye yoke yourselves with such foolish things? Why do ye look for a Christ? For no man can know of anything which is to come.

Behold, these things which ye call prophecies, which ye say are handed down by holy prophets, behold, they are foolish traditions of your fathers.

How do ye know of their surety? Behold, ye cannot know of things which ye do not see; therefore ye cannot know that there shall be a Christ.

Ye look forward and say that ye see a remission of your sins. But behold, it is the effect of a frenzied mind; and this derangement of your minds comes because of the traditions of your fathers, which lead you away into a belief of things which are not so.

And many more such things did he say unto them, telling them that there could be no atonement made for the sins of men, but every man fared in this life according to the management of the creature; therefore every man prospered according to his genius, and that every man conquered according to his strength; and whatsoever a man did was no crime.

18 Мөн тийн тэрээр тэдэнд номлож, олны зүрх сэтгэлийг дагуулан удирдаж, тэднийг ёс бусдаа толгойгоо өргөхөд хүргэв, тийм ээ, олон эмэгтэйчүүдийг мөн түүнчлэн эрчүүдийг садар самууныг үйлдэхэд хүргэв—хүн үхэхэд түүний төгсгөл нь тэр хэмээн тэдэнд хэлж байв.

19 Эдүгээ энэ хүн түүнчлэн Жершоны нутагт нэгэнтээ леменчүүдийн хүмүүс асан Аммоны хүмүүсийн дунд эдгээр зүйлийг номлохоор очив.

20 Гэвч болгоогтун тэд нифайчуудын олноос илүү цэцэн байв; учир нь тэд түүнийг барьж, мөн түүнийг хүлж, мөн уг хүмүүсийн дээрх дээд санваартан асан Аммоны өмнө түүнийг авчрав.

21 Мөнхүү улиран тохиох дор тэрээр түүнийг уг нутгаас гаргуулав. Мөн тэрээр Гидсоны нутагт ирж, мөн түүнчлэн тэдэнд номлож эхлэв; мөн энд тэрээр их амжилттай байсангүй, учир нь тэрээр баривчлагдан мөн хүлэгдэж мөн дээд санваартны мөн түүнчлэн уг нутгийн дээрх ерөнхий шүүгчийн өмнө аваачигдав.

22 Мөнхүү улиран тохиох дор дээд санваартан түүнд хэлэв: Та яагаад Их Эзэний замуудыг гажуудуулан явдаг билээ? Та яагаад энэ хүмүүст, тэдний баяслыг сарниулахаар Христ гэж үгүй хэмээн заадаг билээ? Та яагаад ариун бошиглогчдын бүх бошиглолын эсрэг ярьдаг билээ

23 Эдүгээ уг дээд санваартны нэр нь Гиддона байв. Мөн Корихор түүнд хэлэв: Би танай эцэг өвгөдийн мунхаг уламжлалуудыг заадаггүй учир, мөн тэдний дээр хүч мөн эрх мэдлийг эзэрхийлэхээр, тэднийг харанхуй бүдүүлэг байдалд байлгахаар, тэд толгойгоо эс өргөн, харин таны үгсийн дагуу дагуулагдаж болохын тулд зөнөг санваартнуудаар тогтоогдсон тэр мунхаг ёслол мөн зан үйлүүдийн дор өөрсдийгөө хүлэхийг энэ хүмүүст би заадаггүйн учир болой.

24 Та нар энэ хүмүүсийг чөлөөт хүмүүс хэмээн хэлдэг. Болгоогтун, тэднийг дарангуйлалд байна гэж би хэлнэ. Та нар эртний бошиглолууд үнэн хэмээн хэлдэг. Болгоогтун, та нар тэдгээрийн үнэнийг мэдэхгүй хэмээн би хэлнэ.

25 Та нар энэ хүмүүсийг эх эцгийнхээ зөрчлийн учир, гэмт мөн унасан хүмүүс хэмээн хэлдэг. Болгоогтун, эх эцгийнхээ улмаас хүүхэд нь гэмтэй байдаггүйг би хэлнэ.

And thus he did preach unto them, leading away the hearts of many, causing them to lift up their heads in their wickedness, yea, leading away many women, and also men, to commit whoredoms—telling them that when a man was dead, that was the end thereof.

Now this man went over to the land of Jershon also, to preach these things among the people of Ammon, who were once the people of the Lamanites.

But behold they were more wise than many of the Nephites; for they took him, and bound him, and carried him before Ammon, who was a high priest over that people.

And it came to pass that he caused that he should be carried out of the land. And he came over into the land of Gideon, and began to preach unto them also; and here he did not have much success, for he was taken and bound and carried before the high priest, and also the chief judge over the land.

And it came to pass that the high priest said unto him: Why do ye go about perverting the ways of the Lord? Why do ye teach this people that there shall be no Christ, to interrupt their rejoicings? Why do ye speak against all the prophecies of the holy prophets?

Now the high priest's name was Giddonah. And Korihor said unto him: Because I do not teach the foolish traditions of your fathers, and because I do not teach this people to bind themselves down under the foolish ordinances and performances which are laid down by ancient priests, to usurp power and authority over them, to keep them in ignorance, that they may not lift up their heads, but be brought down according to thy words.

Ye say that this people is a free people. Behold, I say they are in bondage. Ye say that those ancient prophecies are true. Behold, I say that ye do not know that they are true.

Ye say that this people is a guilty and a fallen people, because of the transgression of a parent. Behold, I say that a child is not guilty because of its parents.

- 26 Мөн та нар түүнчлэн Христ ирэх болно хэмээн хэлдэг. Гэвч болгоогтун, Христ байдгийг та нар мэдэхгүй хэмээн би хэлнэ. Мөн та нар түүнчлэн тэрээр дэлхийн нүглүүдийн төлөө егүүтгэгдэх болно гэж хэлдэг—
- 27 Мөн тийн та нар, эцэг өвгөдийнхөө мунхаг уламжлалаар, мөн өөрсдийн хүслийн дагуу энэ хүмүүсийг зайцуулан удирддаг; мөн та нар өөрсдийгөө тэдний гарын хөдөлмөрөөр хөрөнгөжүүлэхийн тулд, мөн тэд өөрсдийн эрх хийгээд боломжууддаа баясаж зүрхлэхгүй байлгахын тулд, мөн тэднийг зоригтойгоор дээш харж зүрхлэхгүй байлгахын тулд та нар тэднийг бүр дарангуйлалд байгаа мэтээр дорд байлгадаг.
- 28 Тийм ээ, тэднийг өөрсдийн хүслийн дагуу буулганд зүтгүүлэх, өөрсдийн уламжлалууд мөн өөрсдийн зүүд хийгээд өөрсдийн дур хүсэл хийгээд өөрсдийн үзэгдэл мөн өөрсдийн нууцууд гэгчээрээ тэднийг, хэрэв тэд өөрсдийнх нь үгсийн дагуу үл үйлдвээс тэдний Бурхан гэж хэлэх, үл мэдэгдэх биеийг гомдооно хэмээн итгэхэд хүргэсэн санваартнууддаа гомдоох вий хэмээн тэд өөрсдийнхөө юмыг ашиглаж эс зүрхэлдэг—хэзээ ч харагдаагүй эсвээс мэдэгдээгүй, хэзээ ч байгаагүй эсвээс бас байдаггүй тэрхүү биеийг бөлгөө.
- 29 Эдүгээ дээд санваартан мөн ерөнхий шүүгч, түүний зүрх сэтгэлийн хатууг хараад, тийм ээ, тэд түүнийг бүр Бурханыг эсэргүүцэхийг нь хараад, тэд түүний үгсэд ямар ч хариу өгсөнгүй; харин тэд түүнийг хүлүүлж; мөн тэд түүнийг түшмэдийн гарт хүргэж, мөн түүнийг бүх нутгийн дээрх засаглагч асан ерөнхий шүүгч болон Алмагийн өмнө аваачиж болохын тулд, түүнийг Зарахемлагийн нутаг тийш илгээв.
- 30 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Алма болон ерөнхий шүүгчийн өмнө авчрагдаад тэрээр Гидеоны нутагт ашигласныхаа адилаар ашигласан эхлэв; тийм ээ, тэрээр Бурханыг доромжлов.
- 31 Мөн тэрээр Алмагийн өмнө дуу хадаан ярив, мөн санваартнууд болон багш нарыг эсэргүүцэн доромжилж, хүмүүсийн хөдөлмөрөөр хөрөнгөжүүлэгдэх гэсэн шалтгааны учир хүмүүсийг эцэг өвгөдийнхөө хөгийн уламжлалуудад удирддаг хэмээн тэднийг буруутгаж байв.

And ye also say that Christ shall come. But behold, I say that ye do not know that there shall be a Christ. And ye say also that he shall be slain for the sins of the world—

And thus ye lead away this people after the foolish traditions of your fathers, and according to your own desires; and ye keep them down, even as it were in bondage, that ye may glut yourselves with the labors of their hands, that they durst not look up with boldness, and that they durst not enjoy their rights and privileges.

Yea, they durst not make use of that which is their own lest they should offend their priests, who do yoke them according to their desires, and have brought them to believe, by their traditions and their dreams and their whims and their visions and their pretended mysteries, that they should, if they did not do according to their words, offend some unknown being, who they say is God—a being who never has been seen or known, who never was nor ever will be.

Now when the high priest and the chief judge saw the hardness of his heart, yea, when they saw that he would revile even against God, they would not make any reply to his words; but they caused that he should be bound; and they delivered him up into the hands of the officers, and sent him to the land of Zarahemla, that he might be brought before Alma, and the chief judge who was governor over all the land.

And it came to pass that when he was brought before Alma and the chief judge, he did go on in the same manner as he did in the land of Gideon; yea, he went on to blaspheme.

And he did rise up in great swelling words before Alma, and did revile against the priests and teachers, accusing them of leading away the people after the silly traditions of their fathers, for the sake of glutting on the labors of the people.

32 Эдүгээ Алма түүнд хэлэв: Бид өөрсдийгөө энэ хүмүүсийн хөдөлмөрөөр хөрөнгөжүүлээгүйг та мэднэ; учир нь болгоогтун би бүр шүүгчдийн засаглалын эхлэлээс одоог хүртэл Бурханы үгийг өөрийн хүмүүст тунхаглахаар нутгийг тойрч олон аялдаг хэдий ч өөрийгөө тэтгэхийн тулд би өөрийнхөө гараар хөдөлмөрлөдөг бөлгөө.

33 Мөн сүмд гүйцэтгэсэн олон хөдөлмөр надад буй хэдий ч, би хэзээ ч өөрийнхөө хөдөлмөрт бүр нэг синайны дайтайг ч хүлээн авч байгаагүй; бас миний ах дүүс шүүхийн суудалд байснаас бусдаар бол тэгж байгаагүй; мөн тэгээд бид зөвхөн ажилласан цагаараа хуулийн дагуу хөлс авч байсан билээ.

34 Мөн эдүгээ, хэрэв бид сүм дэх өөрсдийн хөдөлмөрийн төлөө юу ч хүлээн авдаггүй болохоор, сүмд хөдөлмөрлөхөд бидэнд өөрсдөө ах дүүсийнхээ баясалд баярлаж болохын тулд үнэнийг тунхаглахаас өөр ямар ашиг бидэнд буй билээ

35 Тэгвэл биднийг өргөл хураахын тулд энэ хүмүүст номлодог хэмээн, бид өргөл барьц авдаггүйг мэдсээр байж та яагаад өөрөө ийн хэлж байна вэ? Мөн эдүгээ, тэдний зүрх сэтгэлд ийм баясал төрүүлдэг түүгээр энэ хүмүүсийг хуурч мэхэлдэг хэмээн та итгэдэг үү

36 Мөн Корихор түүнд, Тийм гэж хариулав.

37 Мөн тэгэхэд Алма түүнд хэлэв: Та Бурхан байдагт итгэдэг үү

38 Мөн тэрээр Үгүй гэж хариулав.

39 Эдүгээ Алма түүнд хэлэв: Та Бурхан байдгийг дахин үгүйсгэлээ, мөн түүнчлэн Христийг үгүйсгэх үү? Учир нь болгоогтун, би танд хэлнэ, Бурхан байдгийг, мөн түүнчлэн Христ ирэх болно гэдгийг би мэднэ.

40 Мөн эдүгээ Бурхан байдаггүй, эсвээс Христ ирэхгүй гэсэн ямар нотолгоо танд байна? Зөвхөн таны үгнээс өөр, танд юу ч үгүйг би танд хэлнэ.

41 Гэвч болгоогтун, эдгээр зүйл үнэн гэсэн гэрчлэл болж надад бүх зүйл байдаг; мөн түүнчлэн танд ч тэдгээр нь үнэн хэмээн өөрт чинь гэрчлэл болох бүх зүйл байгаа; мөн та тэднийг үгүйсгэх үү? Эдгээр зүйл үнэн гэдэгт та итгэдэг үү

Now Alma said unto him: Thou knowest that we do not glut ourselves upon the labors of this people; for behold I have labored even from the commencement of the reign of the judges until now, with mine own hands for my support, notwithstanding my many travels round about the land to declare the word of God unto my people.

And notwithstanding the many labors which I have performed in the church, I have never received so much as even one senine for my labor; neither has any of my brethren, save it were in the judgment-seat; and then we have received only according to law for our time.

And now, if we do not receive anything for our labors in the church, what doth it profit us to labor in the church save it were to declare the truth, that we may have rejoicings in the joy of our brethren?

Then why sayest thou that we preach unto this people to get gain, when thou, of thyself, knowest that we receive no gain? And now, believest thou that we deceive this people, that causes such joy in their hearts?

And Korihor answered him, Yea.

And then Alma said unto him: Believest thou that there is a God?

And he answered, Nay.

Now Alma said unto him: Will ye deny again that there is a God, and also deny the Christ? For behold, I say unto you, I know there is a God, and also that Christ shall come.

And now what evidence have ye that there is no God, or that Christ cometh not? I say unto you that ye have none, save it be your word only.

But, behold, I have all things as a testimony that these things are true; and ye also have all things as a testimony unto you that they are true; and will ye deny them? Believest thou that these things are true?

- 42 Болгоогтун, таны итгэдгийг би мэднэ, гэвч та худалч сүнсэнд эзэмдүүлэгдэж, мөн таны дотор зай эзлэхгүй байж болохын тулд Бурханы Сүнсийг та холдуулжээ; харин чөтгөр таныг захирах хүчийг агуулдаг, мөн тэр Бурханы хүүхдүүдийг устгаж болохын тулд зальт төлөвлөгөөгөө гүйцэтгэн таныг дагуулж явдаг бөлгөө.
- 43 Мөн эдүгээ Корихор Алмад хэлэв: Хэрэв та надад би Бурхан байдагт үнэмшүүлэгдэж болохын тулд тэмдгийг, тийм ээ, надад тэрээр хүчтэй гэдгийг үзүүлэх аваас, мөн тэгвэл би таны үгсийн үнэнд үнэмшүүлэгдэх болно.
- 44 Гэвч Алма түүнд хэлэв: Танд хангалттай тэмдгүүд байсан; та Бурханаа сорих гэж үү? Танд эдгээр бүх ах дүүсийн чинь, мөн түүнчлэн бүх ариун бошиглогчдын гэрчлэл байхад, надад тэмдэг үзүүл хэмээн хэлэх гэж үү? Судрууд таны өмнө дэлгээстэй байна, тийм ээ, мөн бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг; тийм ээ, бүр газар дэлхий, мөн үүний гадаргуу дээрх бүх зүйл, тийм ээ, мөн үүний хөдөлгөөн, тийм ээ, мөн түүнчлэн өөрсдийн байнгын замаар хөдлөх тэр бүх гарагууд Эрхэм дээд Бүтээгч байдгийг гэрчилдэг юм.
- 45 Мөн та тийм хэдий ч, энэ хүмүүсийн зүрх сэтгэлийг зайцуулан удирдаж, Бурхан байдаггүйг тэдэнд гэрчилсээр явах уу? Мөн та эдгээр бүх гэрчүүдийн эсрэг үгүйсгэсээр л байх уу? Мөн тэрээр хэлэв: Тийм ээ, надад тэмдэг үзүүлэхгүй аваас би үгүйсгэх болно.
- 46 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма түүнд хэлэв: Болгоогтун, таны зүрх сэтгэл хатуугийн учир, тийм ээ, таны бодгаль устгагдаж болохын тул, та үнэний сүнсийг эсэргүүцсээр байна хэмээн гашууднам би.
- 47 Гэвч болгоогтун, бодгаль тань алдагдах нь, та өөрийн худал хийгээд зусар үгсээрээ олон бодгалийг устгал уруу аваачих арга байснаас илүү дээр билээ; тиймийн тул хэрэв та дахин үгүйсгэвэл, болгоогтун та хэлгүй болж, та дахин хэзээ ч амаа нээж чадахгүй, та дахин энэ хүмүүсийг мэхлэхгүйн тулд Бурхан таныг цохих болно.
- 48 Эдүгээ Корихор түүнд хэлэв: Би Бурхан оршдогийг үгүйсгэхгүй, гэвч би Бурхан байдагт итгэдэггүй; мөн түүнчлэн та нар Бурхан байдгийг мэдэхгүй хэмээн би хэлнэ; мөн та нар надад тэмдэг үзүүлэхгүй бол, би итгэхгүй.

Behold, I know that thou believest, but thou art possessed with a lying spirit, and ye have put off the Spirit of God that it may have no place in you; but the devil has power over you, and he doth carry you about, working devices that he may destroy the children of God.

And now Korihor said unto Alma: If thou wilt show me a sign, that I may be convinced that there is a God, yea, show unto me that he hath power, and then will I be convinced of the truth of thy words.

But Alma said unto him: Thou hast had signs enough; will ye tempt your God? Will ye say, Show unto me a sign, when ye have the testimony of all these thy brethren, and also all the holy prophets? The scriptures are laid before thee, yea, and all things denote there is a God; yea, even the earth, and all things that are upon the face of it, yea, and its motion, yea, and also all the planets which move in their regular form do witness that there is a Supreme Creator.

And yet do ye go about, leading away the hearts of this people, testifying unto them there is no God? And yet will ye deny against all these witnesses? And he said: Yea, I will deny, except ye shall show me a sign.

And now it came to pass that Alma said unto him: Behold, I am grieved because of the hardness of your heart, yea, that ye will still resist the spirit of the truth, that thy soul may be destroyed.

But behold, it is better that thy soul should be lost than that thou shouldst be the means of bringing many souls down to destruction, by thy lying and by thy flattering words; therefore if thou shalt deny again, behold God shall smite thee, that thou shalt become dumb, that thou shalt never open thy mouth any more, that thou shalt not deceive this people any more.

Now Korihor said unto him: I do not deny the existence of a God, but I do not believe that there is a God; and I say also, that ye do not know that there is a God; and except ye show me a sign, I will not believe.

49 Эдүгээ Алма түүнд хэлэв: Үүнийг би тэмдэг болгон танд өгөх болно, та миний үгсийн дагуу цочирдон хэлгүй болгогдох болно; мөн би Бурханы нэрээр, та дахин дуугарахгүй болохын тулд хэлгүй байх болно хэмээн хэлнэ.

50 Эдүгээ Алма эдгээр үгийг хэлэхэд, Корихор Алмагийн үгсийн дагуу дуугарч чадахгүй, хэлгүй болгогдов.

51 Мөн эдүгээ ерөнхий шүүгч үүнийг хараад, тэрээр гараа сунган мөн Корихорт бичиж, өгүүлсэн нь: Та Бурханы хүчинд үнэмшүүлэгдэв үү? Алма өөрийн тэмдгийг хэний дээр үзүүлээсэй хэмээн та хүссэн билээ? Тэрээр танд тэмдэг үзүүлэхийн тулд бусдыг зовоохыг та хүсэв үү? Болгоогтун, тэрээр танд тэмдэг үзүүллээ; мөн эдүгээ та дахин маргах уу

52 Мөн Корихор гараа сунгаж мөн бичиж, өгүүлсэн нь: Би хэлгүй гэдгээ мэднэ, учир нь би ярьж чадахгүй байна; мөн би Бурханы хүчээс өөр юу ч үүнийг миний дээр авчирч чадахгүйг мэднэ; тийм ээ, мөн би Бурхан байдгийг ямагт мэддэг байсан.

53 Гэвч болгоогтун, чөтгөр намайг мэхэлжээ; учир нь тэрээр надад тэнгэр элчийн дүрээр үзэгдэж, мөн надад: явагтун мөн энэ хүмүүсийг буцаан тат, учир нь тэд бүгд үл мэдэгдэх Бурханы хойноос төөрөлдөн одов хэмээн хэлсэн билээ. Мөн тэрээр надад хэлсэн нь: Бурхан гэж үгүй; тийм ээ, мөн тэрээр миний хэлэх ёстойг заасан. Мөн би түүний үгсийг заасан; мөн тэдгээр нь эгэл оюунд таалагдах байсан учир би тэдэнд заасан; мөн би тэдгээрийг, бүр их амжилтанд хүртлээ заасан, үүний хэрээр би тэдгээр нь үнэхээр үнэн гэдэгт итгэсэн билээ; мөн үүний учир би үнэнийг, бүр өөр дээрээ энэ их зүхлийг авчрах хүртлээ сөрөн зогссон бөлгөө.

54 Эдүгээ тэр үүнийг хэлээд, тэрээр уг зүхэл түүнээс авагдаж болохын тулд, Бурханд залбирахыг Алмагаас гуйв.

55 Гэвч Алма түүнд хэлэв: Хэрэв энэ зүхэл танаас авагдах юм бол та дахин энэ хүмүүсийн зүрх сэтгэлийг зайцуулан удирдана; тиймийн тул, энэ нь танд бүр Их Эзэний тааллын дагуу байх болно.

Now Alma said unto him: This will I give unto thee for a sign, that thou shalt be struck dumb, according to my words; and I say, that in the name of God, ye shall be struck dumb, that ye shall no more have utterance.

Now when Alma had said these words, Korihor was struck dumb, that he could not have utterance, according to the words of Alma.

And now when the chief judge saw this, he put forth his hand and wrote unto Korihor, saying: Art thou convinced of the power of God? In whom did ye desire that Alma should show forth his sign? Would ye that he should afflict others, to show unto thee a sign? Behold, he has showed unto you a sign; and now will ye dispute more?

And Korihor put forth his hand and wrote, saying: I know that I am dumb, for I cannot speak; and I know that nothing save it were the power of God could bring this upon me; yea, and I always knew that there was a God.

But behold, the devil hath deceived me; for he appeared unto me in the form of an angel, and said unto me: Go and reclaim this people, for they have all gone astray after an unknown God. And he said unto me: There is no God; yea, and he taught me that which I should say. And I have taught his words; and I taught them because they were pleasing unto the carnal mind; and I taught them, even until I had much success, inasmuch that I verily believed that they were true; and for this cause I withstood the truth, even until I have brought this great curse upon me.

Now when he had said this, he besought that Alma should pray unto God, that the curse might be taken from him.

But Alma said unto him: If this curse should be taken from thee thou wouldst again lead away the hearts of this people; therefore, it shall be unto thee even as the Lord will.

56 Мөнхүү улиран тохиох дор уг зүхэл Корихороос авагдсангүй; харин тэр зайлуулагдаж, мөн хоолоо олохын тулд байрнаас байранд гуйлга гуйн явах болжээ.

57 Эдүгээ Корихорт юу тохиолдсон тухай мэдээ тэр даруй бүх нутаг даяар зарлагдав; тийм ээ, Корихорын үгсэд итгэсэн тэд даруй наманчлах ёстой, үгүй бол нэгэн адил шүүлт тэдний дээр ирнэ хэмээх зар ерөнхий шүүгчээр уг нутаг дахь бүх хүмүүст илгээгдсэн байв.

58 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд Корихорын ёс бусад үнэмшүүлэгдсэн байв; тиймийн тул тэд бүгд дахин Их Эзэнд хөрвүүлэгдэв; мөн энэ нь Корихорын маягийг дагах алдсуудыг эцэс болгов. Мөн Корихор байрнаас байр хэсч, өөрийгөө тэтгэх хүнс гуйж явсан болой.

59 Мөнхүү улиран тохиох дор тэр хүмүүсийн дунд орохдоо, тийм ээ, өөрсдийгөө нифайчуудаас тусгаарлан мөн зорамчууд гэж өөрсдийгөө нэрлэсэн, Зорам гэгч нэртэй түүгээр удирдуулж асан хүмүүсийн дунд—мөн тэрээр тэдний дунд одох үед, болгоогтун, бүр үхэх хүртлээ тэрээр нухчигдан мөн дэвслэгдэв.

60 Мөн тийн Их Эзэний замуудыг гажуудуулагч түүний төгсгөлийг бид харав; мөн тийн чөтгөр эцсийн өдөр өөрийн хүүхдийг эс дэмждэгийг, харин тэднийг яаран там уруу чирэдгийг бид харав.

And it came to pass that the curse was not taken off of Korihor; but he was cast out, and went about from house to house begging for his food.

Now the knowledge of what had happened unto Korihor was immediately published throughout all the land; yea, the proclamation was sent forth by the chief judge to all the people in the land, declaring unto those who had believed in the words of Korihor that they must speedily repent, lest the same judgments would come unto them.

And it came to pass that they were all convinced of the wickedness of Korihor; therefore they were all converted again unto the Lord; and this put an end to the iniquity after the manner of Korihor. And Korihor did go about from house to house, begging food for his support.

And it came to pass that as he went forth among the people, yea, among a people who had separated themselves from the Nephites and called themselves Zoramites, being led by a man whose name was Zoram—and as he went forth amongst them, behold, he was run upon and trodden down, even until he was dead.

And thus we see the end of him who perverteth the ways of the Lord; and thus we see that the devil will not support his children at the last day, but doth speedily drag them down to hell.

## Алма 31

- 1 Эдүгээ улиран тохиох дор Корихорын төгсгөлийн дараа, зорамчууд Их Эзэний замуудыг гажуудуулж байна, мөн тэдний удирдагч Зорам хүмүүсийн зүрх сэтгэлийг амьгүй шүтээнүүдэд бөхийхөд удирдаж байна гэсэн мэдээг Алма хүлээн авч, түүний зүрх сэтгэл уг хүмүүсийн алдсуудын учир дахин шаналж эхлэв.
- 2 Учир нь өөрийн хүмүүсийн дундах алдсуудыг мэдсэн нь Алмад их гуниг харамслыг төрүүлэв; тиймийн тул зорамчууд нифайчуудаас тусгаарласны учир түүний зүрх сэтгэл үлэмж хямрав.
- 3 Эдүгээ зорамчууд өөрсдөө Зарахемла нутгийн дорнод дахь, тэнгисийн эрэгт ойрхноор хиллэж байсан, Жершоны нутгийн өмнөдөд байсан, түүнчлэн өмнөд талаараа леменчүүдээр дүүрэн байх тэр аглаг буйдтай хиллэсэн Антионум гэж нэрлэсэн нутагтаа нэгдэн цугларцгаасан байв.
- 4 Эдүгээ нифайчууд, зорамчууд леменчүүдтэй харилцаанд орох вий хэмээн, мөн энэ нь нифайчуудын талд агуу алдагдлын шалтгаан болох вий хэмээн ихээр айв.
- 5 Мөн эдүгээ, шударга байсан түүнийг хийхэд хүмүүсийг удирдахад үгийг номлох нь их нөлөө болж байсан учир—тийм ээ, энэ нь хүмүүсийн оюун ухаанд илднээс, эсвээс тэдэнд тохиолдсон юунаас ч илүү хүчтэйгээр нөлөө үзүүлж байв—тиймийн тул тэд Бурханы үгийн нөлөөлөх хүчийг сорих нь зайлшгүй болов хэмээн Алма боджээ.
- 6 Тиймийн тул тэрээр Аммон, мөн Аарон, мөн Омнерыг авч; мөн тэрээр Химнайг Зарахемла дахь сүмд орхиж; харин дээрх гурвыг тэрээр өөртэйгөө авчээ түүнчлэн Мелект байсан Амулек мөн Зиезромыг; мөн түүнчлэн тэрээр хөвгүүдийнхээ хоёрыг нь авав.
- 7 Эдүгээ тэрээр хөвгүүдийнхээ ахмадыг нь өөртэйгөө авсангүй, мөн түүний нэр Хиламан байв; харин тэрээр өөртэйгөө авсан тэдний нэрс нь Шиблон мөн Кориантон нар байв; мөн эдгээр нь түүнтэй хамт зорамчуудын дунд тэдэнд үгийг номлохоор одсон тэдний нэрс бөлгөө.

## Alma 31

Now it came to pass that after the end of Korihor, Alma having received tidings that the Zoramites were perverting the ways of the Lord, and that Zoram, who was their leader, was leading the hearts of the people to bow down to dumb idols, his heart again began to sicken because of the iniquity of the people.

For it was the cause of great sorrow to Alma to know of iniquity among his people; therefore his heart was exceedingly sorrowful because of the separation of the Zoramites from the Nephites.

Now the Zoramites had gathered themselves together in a land which they called Antionum, which was east of the land of Zarahemla, which lay nearly bordering upon the seashore, which was south of the land of Jershon, which also bordered upon the wilderness south, which wilderness was full of the Lamanites.

Now the Nephites greatly feared that the Zoramites would enter into a correspondence with the Lamanites, and that it would be the means of great loss on the part of the Nephites.

And now, as the preaching of the word had a great tendency to lead the people to do that which was just—yea, it had had more powerful effect upon the minds of the people than the sword, or anything else, which had happened unto them—therefore Alma thought it was expedient that they should try the virtue of the word of God.

Therefore he took Ammon, and Aaron, and Omner; and Himni he did leave in the church in Zarahemla; but the former three he took with him, and also Amulek and Zezrom, who were at Melek; and he also took two of his sons.

Now the eldest of his sons he took not with him, and his name was Helaman; but the names of those whom he took with him were Shiblon and Corianton; and these are the names of those who went with him among the Zoramites, to preach unto them the word.



- 8 Эдүгээ зорамчууд бол нифайчуудаас тэрслэгчид байв; тиймийн тул Бурханы үг тэдэнд номлогдсон ажээ.
- 9 Гэвч тэд их төөрөгдлүүдэд унасан байв, учир нь тэд Бурханы зарлигууд хийгээд түүний тогтоолуудыг Мосегийн хуулийн дагуу дагахыг чармайсангүй бөлгөө.
- 10 Бас тэд уруу таталтанд орохгүй байж болохын тулд, Бурханд хандан өдөр бүрийн залбирал болоод гуйлтаа үргэлжлүүлэх гэсэн тэр сүмийн үйлүүдийг тэд анхааран үзсэнгүй билээ.
- 11 Тийм ээ, эцсийн дүнд, тэд маш олон тохиолдолд Их Эзэний замуудыг гажуудуулж байв; тиймийн тул, энэ шалтгааны учир, Алма болон түүний ах дүүс уг нутагт тэдэнд үгийг номлохоор одов.
- 12 Эдүгээ, тэд уг нутагт ирсний дараа, болгоогтун, тэдний гайхлыг төрүүлсэн нь зорамчууд синагогууд барьсан явдал байв, мөн тэд Их Эзэний өдөр гэж нэрлэсэн долоо хоногийн нэг өдөр өөрсдөө нэгдэн цуглардаг байв; мөн тэд Алма болон түүний ах дүүсийн хэзээ ч хараагүй тийм маягаар сүсэглэдэг болохыг тэд олж мэдэв.
- 13 Тухайлбал тэд синагогийнхаа төвд толгойноос өндөрт өргөгдсөн, дээр нь зогсох индэр барьсан байлаа; мөн түүний дээр зөвхөн нэг хүн багтах ажээ.
- 14 Тиймийн тул, шүтэн сүсэглэхийг хүссэн хэн боловч явж мөн үүний орой дээр нь зогсоод, мөн тэнгэрийн зүг гараа сунган, мөн чанга дуугаар:
- 15 Ариун, ариун Бурхан; та бол Бурхан, мөн та бол ариун гэдэгт бид итгэдэг, мөн та сүнс байсан, мөн та бол сүнс, та үүрд сүнс байх болно гэдэгт бид итгэдэг гэж хэлэн хашгирах ёстой аж.
- 16 Ариун Бурхан, та биднийг ах дүүсээс маань салгасан гэдэгт бид итгэдэг; мөн тэдний эцэг өвгөдийн гэнэн тэнэгээр тэдэнд гардуулагдсан ах дүүсийнхээ уламжлалуудад бид итгэдэггүй; харин та биднийг өөрийн ариун хүүхдүүд байхаар сонгосон гэдэгт бид итгэдэг; мөн түүнчлэн Христ гэж үгүй байх болно гэдгийг та бидэнд мэдүүлж өгсөн билээ.

Now the Zoramites were dissenters from the Nephites; therefore they had had the word of God preached unto them.

But they had fallen into great errors, for they would not observe to keep the commandments of God, and his statutes, according to the law of Moses.

Neither would they observe the performances of the church, to continue in prayer and supplication to God daily, that they might not enter into temptation.

Yea, in fine, they did pervert the ways of the Lord in very many instances; therefore, for this cause, Alma and his brethren went into the land to preach the word unto them.

Now, when they had come into the land, behold, to their astonishment they found that the Zoramites had built synagogues, and that they did gather themselves together on one day of the week, which day they did call the day of the Lord; and they did worship after a manner which Alma and his brethren had never beheld;

For they had a place built up in the center of their synagogue, a place for standing, which was high above the head; and the top thereof would only admit one person.

Therefore, whosoever desired to worship must go forth and stand upon the top thereof, and stretch forth his hands towards heaven, and cry with a loud voice, saying:

Holy, holy God; we believe that thou art God, and we believe that thou art holy, and that thou wast a spirit, and that thou art a spirit, and that thou wilt be a spirit forever.

Holy God, we believe that thou hast separated us from our brethren; and we do not believe in the tradition of our brethren, which was handed down to them by the childishness of their fathers; but we believe that thou hast elected us to be thy holy children; and also thou hast made it known unto us that there shall be no Christ.

17 Гэвч та бол өчигдөр, өнөөдөр, мөн үүрд нэгэн адил; мөн та биднийг аврагдахаар сонгосон, харин бидний эргэн тойронд байгаа бүгдийг өөрийн хилэнгээр доош тамд хаягдахаар сонгосон билээ; учир нь уг ариун чанарт тань, Ай Бурхан, бид танд талархдаг; мөн түүнчлэн тэдний сэтгэлийг танаас холдуулж төөрөгдүүлэн удирдах, Христэд итгэх итгэлд доош хүлэх тэр, ах дүүсийн маань мунхаг уламжлалуудыг бид дагахгүй байж болохын тулд биднийг сонгосонд тань бид талархдаг, Бурхан минь.

18 Мөн үүнчлэн бид сонгогдсон мөн ариун хүмүүс учраас бид танд талархдаг, Ай Бурхан минь. Амен.

19 Эдүгээ улиран тохиох дор Алма болон түүний ах дүүс мөн түүний хөвгүүд эдгээр залбирлыг дуулаад, тэд хэмжээлшгүйгээр цочирдон гайхав.

20 Учир нь болгоогтун, хүн бүр урагшилж мөн эдгээрийн нэгэн адил залбирлуудыг өргөж байв.

21 Эдүгээ уг газар тэднээр Рамеумптом, орчуулбал ариун тавцан хэмээн нэрлэгдсэн байв.

22 Эдүгээ, энэ тавцангаас тэд, хүн бүр, Бурханд хандсан адилхан залбирлаа, тэд түүгээр сонгогдсон хэмээн, мөн тэрээр тэднийг ах дүүсийнх нь уламжлалд эс удирдсан хэмээн, мөн тэдний өөрсдийнх нь зүрх сэтгэл огтхон ч мэдэхгүй ирэх зүйлүүдэд итгэхээр хулгайлагдаагүй хэмээн Бурхандаа талархлаа өргөж байв.

23 Эдүгээ, хүмүүс бүгд энэ маягаар талархал өргөснийхөө дараа, тэд гэртээ эргэж очоод, тэд өөрсдөө мөнөөх ариун индэрт өөрсдийн маягаар талархал өргөхөөр дахин цугларах хүртлээ Бурханыхаа тухай дахин огт ярьдаггүй ажээ.

24 Эдүгээ Алма үүнийг хараад зүрх сэтгэл нь гашуудав; учир нь тэрээр тэд ёс бус мөн гажууд хүмүүс байсныг үзэв; тийм ээ, тэрээр тэдний зүрх сэтгэл алтан дээр, мөн мөнгөн дээр, мөн бүх төрлийн сайн эд бараанууд дээр байрласныг харав.

25 Тийм ээ, мөн тэрээр түүнчлэн тэдний зүрх сэтгэл бардамналдаа агуу онгиргон занд өргөгдсөнийг харав.

26 Мөн тэрээр дуугаа тэнгэрт өргөн, мөн хашгирч, хэлрүүн: Ай хэр удаан, Ай Их Эзэн, та зарц нараа энэ доор бие махбодид, хүмүүний үрсийн дунд бузар ёс бусыг болгоохоор оршин байхыг тэвчих вэ

But thou art the same yesterday, today, and forever; and thou hast elected us that we shall be saved, whilst all around us are elected to be cast by thy wrath down to hell; for the which holiness, O God, we thank thee; and we also thank thee that thou hast elected us, that we may not be led away after the foolish traditions of our brethren, which doth bind them down to a belief of Christ, which doth lead their hearts to wander far from thee, our God.

And again we thank thee, O God, that we are a chosen and a holy people. Amen.

Now it came to pass that after Alma and his brethren and his sons had heard these prayers, they were astonished beyond all measure.

For behold, every man did go forth and offer up these same prayers.

Now the place was called by them Rameumptom, which, being interpreted, is the holy stand.

Now, from this stand they did offer up, every man, the selfsame prayer unto God, thanking their God that they were chosen of him, and that he did not lead them away after the tradition of their brethren, and that their hearts were not stolen away to believe in things to come, which they knew nothing about.

Now, after the people had all offered up thanks after this manner, they returned to their homes, never speaking of their God again until they had assembled themselves together again to the holy stand, to offer up thanks after their manner.

Now when Alma saw this his heart was grieved; for he saw that they were a wicked and a perverse people; yea, he saw that their hearts were set upon gold, and upon silver, and upon all manner of fine goods.

Yea, and he also saw that their hearts were lifted up unto great boasting, in their pride.

And he lifted up his voice to heaven, and cried, saying: O, how long, O Lord, wilt thou suffer that thy servants shall dwell here below in the flesh, to behold such gross wickedness among the children of men?

- 27 Болгоогтун, Ай Бурхан, тэдний зүрх сэтгэл бардамналдаа автагдсан хэдий ч тэд танд залбирна. Болгоогтун, Ай Бурхан, тэд дэлхийн дэмий хоосон зүйлүүдээр ихээр ихэмсэглэж байхдаа, амаараа танд залбирах ажгуу.
- 28 Болгоогтун, Ай Бурхан минь, тэдний үнэт хувцас, мөн тэдний бөгжнүүд, мөн тэдний бугуйвчнууд, мөн тэдний алтан чимгүүд, мөн тэдний өөрсдийгөө гоёсон бүх үнэт зүйлсийг; мөн болгоогтун, тэдний зүрх сэтгэл тэдгээрийн дээр байрлажээ, мөн гэсэн хэдий ч тэд танд залбирч ийн хэлнэ—Бид танд талархаж байна, Ай Бурхан, учир нь бусад нь мөхөх ёстой байхад, бид таны хувьд сонгогдсон хүмүүс.
- 29 Тийм ээ, мөн Христ гэж байхгүй байх болно гэдгийг та тэдэнд мэдүүлсэн хэмээн тэд хэлдэг.
- 30 Ай Их Эзэн Бурхан, энэ хүмүүсийн дунд ийм ёс бус хийгээд үнэнч бус байдлыг та хэр удаан тэвчих билээ? Ай Их Эзэн, өөрийн сул дорой байдалд тэвчээртэй хандах хүчийг та надад өгөөч. Учир нь би сул дорой, мөн энэ хүмүүсийн дундах ийм ёсон бус нь сэтгэлийг минь өвтгөх бөлгөө.
- 31 Ай Их Эзэн, зүрх сэтгэл минь үлэмж харамсана; та бодгалийг минь Христээр тайтгаруулна уу. Ай Их Эзэн та энэ хүмүүсийн алдсын учир, дээр минь ирэх эдгээр зовлонг тэсвэртэйгээр тэвчиж болохын тул надад хүч байж болохыг соёрхоно уу.
- 32 Ай Их Эзэн, бодгалийг минь та тайтгаруулж, мөн надад, мөн түүнчлэн надтай хамт буй миний хамтран ажиллагчдад ч нэгэн адил амжилтыг өгнө үү—тийм ээ, Аммон, мөн Аарон, мөн Омнер, мөн түүнчлэн Амюлек мөн Зиезром, мөн түүнчлэн хоёр хөвгүүнд минь—тийм ээ, бүр эд бүгдийг та тайтгаруулна уу, Ай Их Эзэн, тийм ээ, та тэдний бодгалиудыг Христээр тайтгаруулаач.
- 33 Энэ хүмүүсийн алдсуудын учир тэдний дээр ирэх зовлонгуудыг тэвчиж болохын тулд; хүчтэй байж болохыг та тэдэнд соёрхоно уу.
- 34 Ай Их Эзэн, тэднийг дахин Христээр танд авчрахад амжилттай байхыг та бидэнд соёрхоно уу.

Behold, O God, they cry unto thee, and yet their hearts are swallowed up in their pride. Behold, O God, they cry unto thee with their mouths, while they are puffed up, even to greatness, with the vain things of the world.

Behold, O my God, their costly apparel, and their ringlets, and their bracelets, and their ornaments of gold, and all their precious things which they are ornamented with; and behold, their hearts are set upon them, and yet they cry unto thee and say— We thank thee, O God, for we are a chosen people unto thee, while others shall perish.

Yea, and they say that thou hast made it known unto them that there shall be no Christ.

O Lord God, how long wilt thou suffer that such wickedness and infidelity shall be among this people? O Lord, wilt thou give me strength, that I may bear with mine infirmities. For I am infirm, and such wickedness among this people doth pain my soul.

O Lord, my heart is exceedingly sorrowful; wilt thou comfort my soul in Christ. O Lord, wilt thou grant unto me that I may have strength, that I may suffer with patience these afflictions which shall come upon me, because of the iniquity of this people.

O Lord, wilt thou comfort my soul, and give unto me success, and also my fellow laborers who are with me— yea, Ammon, and Aaron, and Omner, and also Amulek and Zeezrom, and also my two sons—yea, even all these wilt thou comfort, O Lord. Yea, wilt thou comfort their souls in Christ.

Wilt thou grant unto them that they may have strength, that they may bear their afflictions which shall come upon them because of the iniquities of this people.

O Lord, wilt thou grant unto us that we may have success in bringing them again unto thee in Christ.

- 35 Болгоогтун, Ай Их Эзэн, тэдний бодгаль эрхэм үнэт, мөн тэдний олон нь бидний ах дүүс; тиймийн тул, бид тэднийг, ах дүүсээ дахин танд авчирч болохын тулд, Ай Их Эзэн, хүч чадал хийгээд мэргэн ухааныг бидэнд өгөөч.
- 36 Эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр үгийг хэлээд, өөртэйгөө хамт байсан тэд бүгдийн дээр гараа хавсрав. Мөн болгоогтун, тэрээр тэдний дээр гараа хавсрахад, тэд Ариун Сүнсээр дүүргэгдэв.
- 37 Мөн түүний дараа тэд юу идэх, эсвэл юу уух, эсвэл юу өмсөх билээ гэсэн өөрсдийгөө хичээсэн бодолгүйгээр тэд нэг нэгнээсээ салж одов.
- 38 Мөн Их Эзэн тэднийг өлсгөлгүйгээр бас цангаалгүйгээр хангаж байв; тийм ээ, мөн тэрээр түүнчлэн тэдэнд Христийн баясалд автагдаж байснаас бусдаар, өөр зовлонгуудыг үзүүлэхгүйн тулд тэдэнд хүч чадал өгч байв. Эдүгээ энэ нь Алмагийн залбирлын дагуу байв; мөн энэ нь тэрээр итгэлтэйгээр залбирсны учир болой.

Behold, O Lord, their souls are precious, and many of them are our brethren; therefore, give unto us, O Lord, power and wisdom that we may bring these, our brethren, again unto thee.

Now it came to pass that when Alma had said these words, that he clapped his hands upon all them who were with him. And behold, as he clapped his hands upon them, they were filled with the Holy Spirit.

And after that they did separate themselves one from another, taking no thought for themselves what they should eat, or what they should drink, or what they should put on.

And the Lord provided for them that they should hunger not, neither should they thirst; yea, and he also gave them strength, that they should suffer no manner of afflictions, save it were swallowed up in the joy of Christ. Now this was according to the prayer of Alma; and this because he prayed in faith.

## Алма 32

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэд явж, мөн тэдний синагогуудад, мөн тэдний гэрт орж хүмүүст Бурханы үгийг номлож эхлэв; тийм ээ, мөн тэд бүр тэдний гудамжнуудад үгийг номлов.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд ихэд хөдөлмөрлөсний дараа, тэд хүмүүсийн ядуу хэсгийн дунд амжилт олж эхлэв; учир нь болгоогтун, тэд хувцасныхаа муугийн учир синагогуудаас хөөгдсөн ажээ—
- 3 Тиймийн тул өөрсдийн синагогуудад Бурханыг шүтэхээр орох нь, бузар муугийн адил үнэлэгдсэний учир тэдэнд зөвшөөрөгдсөнгүй; тиймийн тул тэд ядуу байв; тийм ээ, тэд ах дүүсээрээ новш мэт үнэлэгддэг байв; тиймийн тул тэд дэлхийн зүйлүүдээр ядуу байв; мөн түүнчлэн тэд зүрх сэтгэлдээ ч ядуу байв.
- 4 Эдүгээ, Алма Онида толгой дээр хүмүүст зааж мөн ярьж байхад, түүнд их олон ард ирэв, бидний тухайлан ярьж байсан, дэлхийн зүйлүүдээр ядуугийн учир, зүрх сэтгэлдээ ядуу асан тэд байлаа.
- 5 Мөн тэд Алмад ирж; мөн тэдний дундаас түрүүнд нь байсан нэг нь түүнд хэлэв: Болгоогтун, миний эдгээр ах дүүс юу хийх билээ, учир нь тэд ядуу зүүдүүгийнхээ учир бүх хүмүүст, тийм ээ, мөн ялангуяа өөрсдийн санваартнуудаар ад үзэгддэг; учир нь, өөрсдийн гараар ихэд хөдөлмөрлөж барьсан синагогуудаас маань биднийг тэд зайлуулав; мөн тэд бидний үлэмж ядуу зүүдүүгийн учир зайлуулав; мөн бидэнд Бурханаа шүтэх газар алга; мөн болгоогтун бид юу хийх билээ
- 6 Мөн эдүгээ Алма үүнийг дуулаад, тэрээр эргэн харж, тэрээр тэр даруй түүнтэй нүүр тулгарч, мөн тэрээр агуу баясалтайгаар болгоов; учир нь зовлонгууд нь тэднийг үнэхээр даруу болгосныг, мөн тэд үгийг сонсоход бэлтгэгдсэнийг тэрээр болгоов.
- 7 Тиймийн тул тэрээр нөгөө ардуудад дахин юу ч хэлсэнгүй; харин тэр гараа сунгаж, мөн үнэхээр гэмшсэн байдалтай байхыг нь харсан тэдэнд хашгирч, мөн тэдэнд хэлэв:
- 8 Та нар зүрх сэтгэлдээ даруу болохыг би болгоож байна; мөн тийм бол адислагдсан болой та нар.

## Alma 32

And it came to pass that they did go forth, and began to preach the word of God unto the people, entering into their synagogues, and into their houses; yea, and even they did preach the word in their streets.

And it came to pass that after much labor among them, they began to have success among the poor class of people; for behold, they were cast out of the synagogues because of the coarseness of their apparel—

Therefore they were not permitted to enter into their synagogues to worship God, being esteemed as filthiness; therefore they were poor; yea, they were esteemed by their brethren as dross; therefore they were poor as to things of the world; and also they were poor in heart.

Now, as Alma was teaching and speaking unto the people upon the hill Onidah, there came a great multitude unto him, who were those of whom we have been speaking, of whom were poor in heart, because of their poverty as to the things of the world.

And they came unto Alma; and the one who was the foremost among them said unto him: Behold, what shall these my brethren do, for they are despised of all men because of their poverty, yea, and more especially by our priests; for they have cast us out of our synagogues which we have labored abundantly to build with our own hands; and they have cast us out because of our exceeding poverty; and we have no place to worship our God; and behold, what shall we do?

And now when Alma heard this, he turned him about, his face immediately towards him, and he beheld with great joy; for he beheld that their afflictions had truly humbled them, and that they were in a preparation to hear the word.

Therefore he did say no more to the other multitude; but he stretched forth his hand, and cried unto those whom he beheld, who were truly penitent, and said unto them:

I behold that ye are lowly in heart; and if so, blessed are ye.

- 9 Болгоогтун, Бид юу хийх билээ?—учир нь бид Бурханаа шүтэж чадахгүй болон бид синагогуудаасаа зайлуулагдав хэмээн ах тань хэллээ.
- 10 Болгоогтун би та нарт хэлнэ, та нар зөвхөн өөрсдийн синагогуудад бус бол Бурханыг шүтэж чадахгүй хэмээн бодно уу
- 11 Мөн үүнээс гадна, та нар Бурханыг долоо хоногт зөвхөн нэг удаа шүтэх ёстой хэмээн бодно уу хэмээн би асууя
- 12 Би та нарт хэлнэ, та нар даруухан байж болохын тулд, мөн та нар мэргэн ухааныг сурч болохын тулд, та нар синагогуудаасаа хөөгдсөн нь сайн болой; учир нь та нар мэргэн ухаанд суралцах нь чухал юм; та нарын үлэмж ядуу зүдүүгийн учир ах дүүсээрээ та нар үзэн ядагдсан ажээ, та нар хөөгдсөн учир, та нар зүрх сэтгэлийн даруу байдалд авчрагдсан ажгуу; учир нь та нар даруу байдалд зайлшгүйгээр авчрагдсан бөлгөө.
- 13 Мөн эдүгээ, та нар даруу байхаар албадагдсан учир та нар адислагдсан болой; учир нь хүн заримдаа, хэрэв тэрээр даруу байхаар албадуулагдсан аваас, наманчлалыг эрэлхийлдэг; мөн эдүгээ наманчилсан хэн боловч нигүүлслийг олох нь гарцаагүй; мөн нигүүлслийг олсон хийгээд эцсийг хүртэл тэвчих тэр нь аврагдах болно.
- 14 Мөн эдүгээ, та нар даруу байхаар албадуулагдсан учир та нар адислагдсан хэмээн би та нарт хэлсэн, үгийн учир өөрсдийгөө үнэхээр даруусгах тэд илүү ихээр адислагдсан хэмээн та нар бодохгүй байна уу
- 15 Тийм ээ, өөрийгөө үнэхээр даруусгадаг, мөн нүглээ наманчилдаг, мөн эцсийг хүртэл тэвчих тэрээр, мөнхүү тэр нь адислагдах болно—тийм ээ, өөрсдийн үлэмж ядуу зүдүүгийнхээ учир даруу байхаар албадагдсан тэднээс бүр илүү ихээр адислагдсан болой.
- 16 Тиймийн тул, даруу байхыг албадуулалгүйгээр өөрсдийгөө даруу болгох тэд адислагдсан болой; эсвээс, өөрөөр хэлбэл, Бурханы үгэнд итгэх, мөн зүрх сэтгэлийн зөрүүдгүйгээр баптисм хүртэх, тийм ээ, итгэхээсээ өмнө үгийг мэдэхээр хүргэгдэлгүйгээр, өөрөөр хэлбэл мэдэхээр албадуулаагүй тэр нь адислагдсан болой.

Behold thy brother hath said, What shall we do?—for we are cast out of our synagogues, that we cannot worship our God.

Behold I say unto you, do ye suppose that ye cannot worship God save it be in your synagogues only?

And moreover, I would ask, do ye suppose that ye must not worship God only once in a week?

I say unto you, it is well that ye are cast out of your synagogues, that ye may be humble, and that ye may learn wisdom; for it is necessary that ye should learn wisdom; for it is because that ye are cast out, that ye are despised of your brethren because of your exceeding poverty, that ye are brought to a lowliness of heart; for ye are necessarily brought to be humble.

And now, because ye are compelled to be humble blessed are ye; for a man sometimes, if he is compelled to be humble, seeketh repentance; and now surely, whosoever repenteth shall find mercy; and he that findeth mercy and endureth to the end the same shall be saved.

And now, as I said unto you, that because ye were compelled to be humble ye were blessed, do ye not suppose that they are more blessed who truly humble themselves because of the word?

Yea, he that truly humbleth himself, and repenteth of his sins, and endureth to the end, the same shall be blessed—yea, much more blessed than they who are compelled to be humble because of their exceeding poverty.

Therefore, blessed are they who humble themselves without being compelled to be humble; or rather, in other words, blessed is he that believeth in the word of God, and is baptized without stubbornness of heart, yea, without being brought to know the word, or even compelled to know, before they will believe.

17 Тийм ээ, хэрэв та бидэнд тэнгэрээс тэмдэг үзүүлбэл, тэгвэл бид гарцаагүй мэдэх болно; тэгвэл бид итгэх болно хэмээн хэлэх гэд олон байдаг.

18 Эдүгээ би асууя, энэ нь итгэл гэж үү? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; учир нь хэрэв хүн аливаа зүйлийг мэддэг аваас итгэх шалтгаангүй, учир нь тэр үүнийг мэддэг.

19 Мөн эдүгээ, Бурханы тааллыг мэддэг мөн үл хийгч тэрээр, итгэх эсвээс зөвхөн итгэх шалтгаан бүхий мөн зөрчилд унадаг түүнээс хичнээн илүүгээр зүхэгдсэн билээ

20 Эдүгээ энэ зүйлийн талаар та нар цэгнэх ёстой. Болгоогтун, би та нарт хэлнэ, энэ нь нэг гар дээр байгаа шиг бүр нөгөө дээр нь ч буй; мөн энэ нь хүн бүрд өөрийн нь үйлийн дагуу байх болно.

21 Мөн эдүгээ миний итгэлийн талаар хэлсэнчлэн — итгэл бол юмсын тухай төгс мэдлэгтэй байх нь бус юм; тиймийн тул хэрэв та нар итгэлтэй аваас та нар үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах болно.

22 Мөн эдүгээ, болгоогтун, Бурхан бол түүний нэрэнд итгэдэг бүгдэд нигүүлсэнгүйг би та нарт хэлнэ, мөн та нарыг санаасай хэмээнэ би; тиймийн тул тэрээр юун түүрүүнд, та нарыг, тийм ээ, бүр түүний үгсэд итгээсэй хэмээн хүсдэг.

23 Мөн эдүгээ, тэрээр өөрийн үгийг тэнгэр элчүүдээр эрчүүдэд, тийм ээ, зөвхөн эрчүүдэд бус харин түүнчлэн эмэгтэйчүүдэд мэдүүлдэг. Эдүгээ энэ нь бүгд бус; бяцхан хүүхдүүдэд ч мэргэнийг мөн эрдэмтнийг ичээх үгс олон удаа тэдэнд өгөгдсөн байдаг.

24 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, та нар зовж мөн хөөгдсөн учир та нар юу хийхээ надаас мэдэхийг хүссэн учир—эдүгээ би зөвхөн үнэн байдлын дагуу та нарыг шүүнэ хэмээн та нарыг бодоосой гэж хүсэхгүй байна би—

25 Учир нь та нар бүгд өөрсдөө даруу байхаар албадуулагдсан гэсэнгүй би; учир нь ямар ч нөхцөл байдалд байсан өөрсдийгөө даруу болгох зарим нь та нарын дунд байгаа гэдэгт би үнэхээр итгэж байна.

Yea, there are many who do say: If thou wilt show unto us a sign from heaven, then we shall know of a surety; then we shall believe.

Now I ask, is this faith? Behold, I say unto you, Nay; for if a man knoweth a thing he hath no cause to believe, for he knoweth it.

And now, how much more cursed is he that knoweth the will of God and doeth it not, than he that only believeth, or only hath cause to believe, and falleth into transgression?

Now of this thing ye must judge. Behold, I say unto you, that it is on the one hand even as it is on the other; and it shall be unto every man according to his work.

And now as I said concerning faith—faith is not to have a perfect knowledge of things; therefore if ye have faith ye hope for things which are not seen, which are true.

And now, behold, I say unto you, and I would that ye should remember, that God is merciful unto all who believe on his name; therefore he desireth, in the first place, that ye should believe, yea, even on his word.

And now, he imparteth his word by angels unto men, yea, not only men but women also. Now this is not all; little children do have words given unto them many times, which confound the wise and the learned.

And now, my beloved brethren, as ye have desired to know of me what ye shall do because ye are afflicted and cast out—now I do not desire that ye should suppose that I mean to judge you only according to that which is true—

For I do not mean that ye all of you have been compelled to humble yourselves; for I verily believe that there are some among you who would humble themselves, let them be in whatsoever circumstances they might.

26 Эдүгээ, итгэлийн талаар миний хэлсэнчлэн—энэ нь төгс мэдлэг биш—үүнчлэн энэ нь миний үгсийн хувьд тийм буй. Итгэл нь төгс мэдлэг бусын адил та нар эхлээд тэдгээрийн лавтайг төгс сайнаар мэдэж чадахгүй.

27 Гэвч болгоогтун, хэрэв та нар бүр миний үгсийг туршин, сэрж мөн чадвараа сэргээх аваас, мөн итгэлийн жижиг хэсгийг ч гэсэн бодит болговол, тийм ээ, бүр та нарт итгэх хүслээс илүү нь байхгүй ч гэсэн, энэ хүслийг өөрсөддөө хөгжихийг, бүр та нар миний үгсийн нэгэн хэсгийг өөртөө байрлуулж чадахаар итгэтлээ зөвшөөр.

28 Эдүгээ, бид үгийг үртэй зүйрлэх болно. Эдүгээ, хэрэв та нар зүрх сэтгэлд тань үр суулгагдаж болохын тулд зай тавьж өгвөөс, болгоогтун, хэрэв энэ нь үнэн үр, эсвээс энэ нь сайн үр аваас, хэрэв та нар Их Эзэний Сүнсийг эсэргүүцэхээр итгэлгүй байдлаараа үүнийг та нар зайлуулахгүй аваас, болгоогтун, энэ нь та нарын цээжинд өсөж эхлэх болно; мөн та нар эдгээр өсөлтийг мэдрээд, та нар өөрсөддөө—Энэ нь сайн үр, өөрөөр хэлбэл үг нь сайн байх ёстой, учир нь энэ нь бодгалийг минь тэлж эхлэв; тийм ээ, энэ нь ойлголтыг минь гэгээрүүлж эхлэв, тийм ээ, энэ нь надад амтат байх болж эхлэв хэмээн хэлж эхлэх болно.

29 Эдүгээ болгоогтун, энэ нь та нарын итгэлийг өсгөх бус уу? Би та нарт хэлнэ, Тийм ээ; гэсэн хэдий ч энэ нь төгс мэдлэгт хүртэл ургаагүй буюу.

30 Гэвч болгоогтун, үр өсөж, мөн соёолж, мөн ургаж эхлэхэд, тэгээд та нар уг үр сайн байх ёстой гэж хэлдэг; учир нь болгоогтун, энэ нь өсдөг, мөн соёолж, мөн ургаж эхэлдэг. Мөн эдүгээ, болгоогтун, энэ нь та нарын итгэлийг хүчирхэгжүүлэхгүй гэж үү? Тийм ээ, энэ нь та нарын итгэлийг хүчирхэгжүүлэх болно: Учир нь би энэ үр сайн гэдгийг мэднэ хэмээн та нар хэлэх болно; учир нь болгоогтун энэ нь соёолж мөн ургаж эхэлдэг.

31 Мөн эдүгээ, болгоогтун, энэ нь сайн үр гэдэг нь та нарт лавтай байна уу? Би та нарт хэлнэ, тийм ээ; учир нь үр болгон өөрийнхөө нэгэн адил үрийг авчирдаг билээ.

32 Тиймийн тул, хэрэв үр ургавал энэ нь сайн, гэвч хэрэв ургахгүй бол, болгоогтун энэ нь сайн биш, тиймийн тул энэ нь хаягдах болно.

Now, as I said concerning faith—that it was not a perfect knowledge—even so it is with my words. Ye cannot know of their surety at first, unto perfection, any more than faith is a perfect knowledge.

But behold, if ye will awake and arouse your faculties, even to an experiment upon my words, and exercise a particle of faith, yea, even if ye can no more than desire to believe, let this desire work in you, even until ye believe in a manner that ye can give place for a portion of my words.

Now, we will compare the word unto a seed. Now, if ye give place, that a seed may be planted in your heart, behold, if it be a true seed, or a good seed, if ye do not cast it out by your unbelief, that ye will resist the Spirit of the Lord, behold, it will begin to swell within your breasts; and when you feel these swelling motions, ye will begin to say within yourselves—It must needs be that this is a good seed, or that the word is good, for it beginneth to enlarge my soul; yea, it beginneth to enlighten my understanding, yea, it beginneth to be delicious to me.

Now behold, would not this increase your faith? I say unto you, Yea; nevertheless it hath not grown up to a perfect knowledge.

But behold, as the seed swelleth, and sprouteth, and beginneth to grow, then you must needs say that the seed is good; for behold it swelleth, and sprouteth, and beginneth to grow. And now, behold, will not this strengthen your faith? Yea, it will strengthen your faith: for ye will say I know that this is a good seed; for behold it sprouteth and beginneth to grow.

And now, behold, are ye sure that this is a good seed? I say unto you, Yea; for every seed bringeth forth unto its own likeness.

Therefore, if a seed groweth it is good, but if it groweth not, behold it is not good, therefore it is cast away.



33 Мөн эдүгээ, болгоогтун, та нар туршиж үзсэн, мөн үрийг тарьсан учир, мөн өсөж мөн соёолж, мөн ургаж эхэлсэн учир, та нар үр нь сайн юм гэдгийг мэдэх учиртай.

34 Мөн эдүгээ, болгоогтун, та нарын мэдлэг төгс үү? Тийм ээ, та нарын мэдлэг тэр зүйлд төгс, мөн та нарын итгэл зогсонги; мөн энэ нь та нар мэддэгийн учир, тодруулбал үг нь та нарын сэтгэлийг өсгөсөн болохыг та нар мэднэ, мөн та нарын ойлголт гэгээрүүлэгдэж эхэлдэг, мөн та нарын оюун тэлж эхэлсэн учир, энэ нь соёолсныг та нар түүнчлэн мэдэх болно.

35 Ай тэгвэл, энэ нь бодитой гэж үү? Би та нарт хэлнэ, Тийм ээ, учир нь энэ бол гэрэл; мөн гэрэл болгон ямар боловч сайн, учир нь энэ бол харагдах зүйл, тиймийн тул та нар энэ нь сайныг мэдэх ёстой; мөн эдүгээ болгоогтун, та нар энэ гэрлийг амталсны дараа мэдлэг тань төгс үү

36 Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; бас та нар итгэлээ орхих ёсгүй, учир нь та нар үрийг сайн эсэхийг мэдэхээр туршин үзэж болохын тулд, зөвхөн үрийг тарихад л итгэлээ бодитой болгосон байдаг.

37 Мөн болгоогтун, мод ургаж эхлэхэд, та нар хэлэх болно: Энэ нь үндэслэж болохын тулд, энэ нь ургаж, мөн бидэнд үр жимс авчирч болохын тулд агуу халамжаар үүнийг арчилцгаая. Мөн эдүгээ болгоогтун, хэрэв та нар үүнийг их халамжаар арчилбаас энэ нь үндэслэн, мөн ургаж, тэгээд үр жимс авчрах болно.

38 Гэвч хэрэв та нар уг модонд хайнга хандаж, мөн үүний арчилгааны талаар эс бодвоос, болгоогтун энэ нь үндэслэхгүй байх болно; мөн нарны илч тусаж, мөн түүнийг шарж төөнөхөд, үндэсгүйн учир хатан хувхайрч, мөн та нар үүнийг сугалж, тэгээд үүнийг хаях болно.

39 Эдүгээ, энэ нь үр сайн бус, эсвээс үүний жимс нь дур булаам бус байснаас болсон биш юм; харин энэ нь газрын чинь үржил шимгүйнх, мөн та нар модыг арчлаагүйнх юм, тиймийн тул та нар үүний жимсийг авч чадахгүй.

40 Мөн тийн, хэрэв үүний жимсийг итгэлийн нүдээр хүсэн хүлээж та нар үгийг арчлахгүй аваас, та нар хэзээ ч амьдралын модны жимснээс түүж чадахгүй.

And now, behold, because ye have tried the experiment, and planted the seed, and it swelleth and sprouteth, and beginneth to grow, ye must needs know that the seed is good.

And now, behold, is your knowledge perfect? Yea, your knowledge is perfect in that thing, and your faith is dormant; and this because you know, for ye know that the word hath swelled your souls, and ye also know that it hath sprouted up, that your understanding doth begin to be enlightened, and your mind doth begin to expand.

O then, is not this real? I say unto you, Yea, because it is light; and whatsoever is light, is good, because it is discernible, therefore ye must know that it is good; and now behold, after ye have tasted this light is your knowledge perfect?

Behold I say unto you, Nay; neither must ye lay aside your faith, for ye have only exercised your faith to plant the seed that ye might try the experiment to know if the seed was good.

And behold, as the tree beginneth to grow, ye will say: Let us nourish it with great care, that it may get root, that it may grow up, and bring forth fruit unto us. And now behold, if ye nourish it with much care it will get root, and grow up, and bring forth fruit.

But if ye neglect the tree, and take no thought for its nourishment, behold it will not get any root; and when the heat of the sun cometh and scorcheth it, because it hath no root it withers away, and ye pluck it up and cast it out.

Now, this is not because the seed was not good, neither is it because the fruit thereof would not be desirable; but it is because your ground is barren, and ye will not nourish the tree, therefore ye cannot have the fruit thereof.

And thus, if ye will not nourish the word, looking forward with an eye of faith to the fruit thereof, ye can never pluck of the fruit of the tree of life.

41 Гэвч хэрэв та нар үгийг арчилбал, тийм ээ, үүнийг ургаж эхлэхэд модыг арчилж, өөрийн агуу шаргуу итгэл хийгээд тэвчээрээр үүнийг хүсэн хүлээх аваас, энэ нь үндэслэх болно; мөн болгоогтун энэ нь үүрдийн амьдралд хүргэх мод байх болно.

42 Мөн энэ нь та нарын дотор үндэслэж болохын тулд, та нар үгийг арчлахдаа зориулсан шаргуу байдал хийгээд та нарын итгэл түүнчлэн та нарын тэвчээрийн учир, болгоогтун, удахгүй та нар үүний жимсийг, хамгийн эрхэм, амтат бүхнээс дээд амтат, мөн цагаан бүхнээс цагаан түүнийг, тийм ээ, цэвэр бүхнээс цэвэр түүнийг түүх болно; мөн та нар бүр цадталаа, та нар өлсөхгүй, бас цангахгүй болтлоо энэ жимсэн дээр найрлах болно.

43 Тэгээд, ах дүүс минь уг мод та нарт жимс өгөхийг хүлээж байх зуур гаргасан итгэлийнхээ, мөн шаргуу байдлынхаа, мөн тэвчээрийнхээ, мөн тэсвэрийнхээ шагналыг та нар хадаж авах болно.

But if ye will nourish the word, yea, nourish the tree as it beginneth to grow, by your faith with great diligence, and with patience, looking forward to the fruit thereof, it shall take root; and behold it shall be a tree springing up unto everlasting life.

And because of your diligence and your faith and your patience with the word in nourishing it, that it may take root in you, behold, by and by ye shall pluck the fruit thereof, which is most precious, which is sweet above all that is sweet, and which is white above all that is white, yea, and pure above all that is pure; and ye shall feast upon this fruit even until ye are filled, that ye hunger not, neither shall ye thirst.

Then, my brethren, ye shall reap the rewards of your faith, and your diligence, and patience, and long-suffering, waiting for the tree to bring forth fruit unto you.

## Алма 33

- 1 Эдүгээ Алма эдгээр үгсийг ярьсны дараа, тэд түүний ярьсан жимсийг хүртэж болохын тулд нэг Бурханд итгэх ёстой эсэхээ, эсвээс тэдний зүрх сэтгэлд суулгагдах ёстой хэмээн түүний хэлсэн тэрхүү үгийг, өөрөөр хэлбэл үрийг тэд хэрхэн тарих ёстойг; эсвээс ямар маягаар тэд итгэлээ хөгжүүлж эхэлбэл зохихыг мэдэхийг хүсч түүнд илгээв.
- 2 Мөн Алма тэдэнд хэлэв: Болгоогтун, та нар синагогуудаасаа хөөгдсөн учир Бурханаа шүтэн биширч чаддаггүй хэмээн хэлэв. Гэвч болгоогтун, би та нарт хэлнэ, хэрэв та нар Бурханыг шүтэн биширч чаддаггүй хэмээн бодвол, та нар маш ихээр алдаж байна, мөн та нар судруудыг судалбал зохино; хэрэв та нар тэдгээр нь та нарт үүнийг заасан гэвэл, та нар тэдгэрийг ойлгодоггүй аж.
- 3 Хуучны бошиглогч Зинос залбирал эсвээс шүтлэгийн талаар юу хэлснийг уншсанаа санаж байна уу
- 4 Учир нь тэр хэлсэн нь: Та нигүүлсэнгүй билээ, Ай Бурхан, учир нь та намайг бүр аглаг буйдад байхад ч залбирлыг минь сонссон; тийм ээ, дайснууд минь байсан тэдний талаар намайг залбирахад та нигүүлсэнгүй байж, мөн та тэднийг миний зүг эргүүлсэн билээ.
- 5 Тийм ээ, Ай Бурхан, мөн намайг талбайдаа танд хандан залбирч байхад та надад нигүүлсэнгүй байсан; намайг залбиралдаа гуйж байхад, мөн та намайг сонссон болой.
- 6 Мөн үүнчлэн, Ай Бурхан, намайг гэрийнхээ зүг эргэхэд ч та намайг залбиралд минь сонссон болой.
- 7 Мөн би гонхондоо орон, Ай Их Эзэн, мөн танд залбирахад, та намайг сонссон болой.
- 8 Тийм ээ, хүмүүнд бус харин танд сонсгохоор залбиран гуйхад нь та хүүхдүүддээ нигүүлсэнгүй байдаг, мөн та тэднийг сонсох болно.
- 9 Тийм ээ, Ай Бурхан, та надад нигүүлсэнгүй байж, мөн гуйлтуудыг минь өөрийн цугласан олны дундаас сонссон билээ.

## Alma 33

Now after Alma had spoken these words, they sent forth unto him desiring to know whether they should believe in one God, that they might obtain this fruit of which he had spoken, or how they should plant the seed, or the word of which he had spoken, which he said must be planted in their hearts; or in what manner they should begin to exercise their faith.

And Alma said unto them: Behold, ye have said that ye could not worship your God because ye are cast out of your synagogues. But behold, I say unto you, if ye suppose that ye cannot worship God, ye do greatly err, and ye ought to search the scriptures; if ye suppose that they have taught you this, ye do not understand them.

Do ye remember to have read what Zenos, the prophet of old, has said concerning prayer or worship?

For he said: Thou art merciful, O God, for thou hast heard my prayer, even when I was in the wilderness; yea, thou wast merciful when I prayed concerning those who were mine enemies, and thou didst turn them to me.

Yea, O God, and thou wast merciful unto me when I did cry unto thee in my field; when I did cry unto thee in my prayer, and thou didst hear me.

And again, O God, when I did turn to my house thou didst hear me in my prayer.

And when I did turn unto my closet, O Lord, and prayed unto thee, thou didst hear me.

Yea, thou art merciful unto thy children when they cry unto thee, to be heard of thee and not of men, and thou wilt hear them.

Yea, O God, thou hast been merciful unto me, and heard my cries in the midst of thy congregations.

10 Тийм ээ, мөн та намайг зайлуулагдаж мөн дайс-  
нуудаараа үзэн ядагдаж байхад та түүнчлэн намайг  
сонссон; тийм ээ, та гуйлгуудыг минь сонссон, мөн  
дайснуудад маань уурласан, мөн та тэдэнд уур хи-  
лэндээ хурдан устгалаар зочилсон болой.

11 Мөн та зовлонгуудын минь мөн чин сэтгэлийн  
минь учир намайг сонссон; мөн таны Хүүгийн учир  
та надад ийн нигүүлсэнгүй байсан, тиймийн тул би  
өөрийн бүх зовлон дунд танаас гуйх болно, учир нь  
танд миний баясал буй; учир нь та өөрийн Хүүгийн  
учир шүүлтүүдээ надаас зайлуулан буцаасан ажгуу.

12 Мөн эдүгээ Алма тэдэнд хэлэв: Та нар хуучны бо-  
лох тэднээр бичигдсэн судруудад итгэдэг үү

13 Болгоогтун, хэрэв тийм бол, та нар Зиносын хэл-  
сэнд итгэх ёстой; учир нь, болгоогтун тэрээр хэлсэн  
нь: Та өөрийн Хүүгийн учир шүүлтүүдээ зайлуулан  
буцаасан ажгуу.

14 Эдүгээ болгоогтун, ах дүүс минь, та нар судруудыг  
уншсан эсэхийг би асууя? Хэрэв та нар тэгсэн бол, та  
нар яахан Бурханы Хүүд итгэлгүй байж чадах билээ

15 Учир нь Зинос ганцаараа эдгээр зүйлийг ярьсан  
гэж бичиглэгдээгүй, харин Зинок түүнчлэн эдгээр  
зүйлийн талаар ярьсан билээ—

16 Учир нь болгоогтун, тэрээр хэлсэн нь: Өөрийн  
Хүүгийн учир тэдний дээр бэлэглэсэн тэрхүү ни-  
гүүлслүүдийг тань ойлгохгүйн учир энэ хүмүүст та  
ууртай байна, Ай Их Эзэн.

17 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар хуучны хоёр дахь  
бошиглогч Бурханы Хүүгийн талаар гэрчилснийг  
харлаа, мөн уг хүмүүс түүний үгсийг ойлгоогүйн  
учир түүнийг үхтэл нь чулуугаар шидсэн ажгуу.

18 Гэвч болгоогтун, энэ нь бүгд бус; зөвхөн эдгээр нь  
Бурханы Хүүгийн талаар ярьсан тэд биш авай.

19 Болгоогтун, тэрээр Мосегоор яригдсан бөлгөө;  
тийм ээ, мөн болгоогтун аглаг буйдад хэв шинж өр-  
гөгдсөн, үүнийг харсан хэн боловч амьдарч болохын  
тулд юм. Мөн олон нь харж мөн амьдрав.

20 Гэвч тэдгээр зүйлийн утгыг ойлгосон нь цөөн,  
мөн энэ нь тэдний зүрх сэтгэл хатуугийн учир бо-  
лой. Харин хатуурсан байснаас харахыг хүсээгүй нь  
олон байв, тиймийн тул тэд мөхсөн юм. Эдүгээ тэд  
харахгүй байсны шалтгаан нь, энэ нь тэднийг эдгээнэ  
гэдэгт тэд итгээгүйгээс юм.

Yea, and thou hast also heard me when I have been  
cast out and have been despised by mine enemies; yea,  
thou didst hear my cries, and wast angry with mine ene-  
mies, and thou didst visit them in thine anger with  
speedy destruction.

And thou didst hear me because of mine afflictions  
and my sincerity; and it is because of thy Son that thou  
hast been thus merciful unto me, therefore I will cry  
unto thee in all mine afflictions, for in thee is my joy; for  
thou hast turned thy judgments away from me, because  
of thy Son.

And now Alma said unto them: Do ye believe those  
scriptures which have been written by them of old?

Behold, if ye do, ye must believe what Zenos said; for,  
behold he said: Thou hast turned away thy judgments  
because of thy Son.

Now behold, my brethren, I would ask if ye have read  
the scriptures? If ye have, how can ye disbelieve on the  
Son of God?

For it is not written that Zenos alone spake of these  
things, but Zenock also spake of these things—

For behold, he said: Thou art angry, O Lord, with  
this people, because they will not understand thy mer-  
cies which thou hast bestowed upon them because of  
thy Son.

And now, my brethren, ye see that a second prophet  
of old has testified of the Son of God, and because the  
people would not understand his words they stoned  
him to death.

But behold, this is not all; these are not the only ones  
who have spoken concerning the Son of God.

Behold, he was spoken of by Moses; yea, and behold a  
type was raised up in the wilderness, that whosoever  
would look upon it might live. And many did look and  
live.

But few understood the meaning of those things,  
and this because of the hardness of their hearts. But  
there were many who were so hardened that they would  
not look, therefore they perished. Now the reason they  
would not look is because they did not believe that it  
would heal them.

- 21 Өө ах дүүс минь, хэрэв та нар эдгээгдэж болохын тулд зөвхөн харц чулуудсанаар эдгээгдэж болдог бол, та нар хурдхан болгоохгүй гэж үү, эсвээс та нар мөхөж болохын тулд та нар харцаа эс чулуудан залхаг байж, итгэлгүй байдалд зүрх сэтгэлээ хатууруулах нь дээр хэмээн үзнэ гэж үү
- 22 Хэрэв тийм аваас, та нарын дээр халаг байх болно; гэвч хэрэв тийм бус аваас, тэгвэл харц чулуудан мөн Бурханы Хүүд, тэрээр өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр ирэх болно гэдэгт, мөн тэрээр тэдний нүглүүдийг цагаатгахаар зовж мөн егүүтгэгдэх болно гэдэгт, бүх хүмүүн эцсийн хийгээд шүүлтийн өдөр үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр түүний өмнө зогсохын тулд тэрээр амилуулалтыг улируулан тохиолгохоор нас барагсдын дундаас босно гэдэгт итгэж эхлэгтүн.
- 23 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар энэ үгийг зүрх сэтгэлдээ тариасай, мөн энэ нь ургаж эхлэхэд та нар итгэлээрээ арчлаасай хэмээн би хүснэ. Мөн болгоогтун, энэ нь танд үүрдийн амьдралд нахиалах нэгэн мод болно. Мөн тэгээд түүний Хүүгийн баяслаар танд үүрэг чинь хөнгөн байж болохыг Бурхан соёрхох болтугай. Мөн хэрэв та нар хүсвэл бүр энэ бүгдийг та нар хийж чадах нь тэр бөлгөө. Амен.

O my brethren, if ye could be healed by merely casting about your eyes that ye might be healed, would ye not behold quickly, or would ye rather harden your hearts in unbelief, and be slothful, that ye would not cast about your eyes, that ye might perish?

If so, wo shall come upon you; but if not so, then cast about your eyes and begin to believe in the Son of God, that he will come to redeem his people, and that he shall suffer and die to atone for their sins; and that he shall rise again from the dead, which shall bring to pass the resurrection, that all men shall stand before him, to be judged at the last and judgment day, according to their works.

And now, my brethren, I desire that ye shall plant this word in your hearts, and as it beginneth to swell even so nourish it by your faith. And behold, it will become a tree, springing up in you unto everlasting life. And then may God grant unto you that your burdens may be light, through the joy of his Son. And even all this can ye do if ye will. Amen.

## Алма 34

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма тэдэнд эдгээр үгсийг ярьсныхаа дараа газар дээр сууж, мөн Амюлек босож мөн тэдэнд сургаж эхлэв, өгүүлсэн нь:
- 2 Ах дүүс минь, биднээр Бурханы Хүү болохыг заагдсан гэр, Христийн ирэлтийн талаар яригдсан зүйлийг үл мэдэх нь боломжгүй хэмээн бодно би; тийм ээ, бидний дундаас та нар тэрслэхээс өмнө эдгээр зүйл та нарт элбэг дэлбэгээр сургагдсаныг мэднэ би.
- 3 Мөн та нар зовлонгуудынхаа учир та нар юу хийвэл зохихыг тэрээр та нарт мэдүүлэхийг хайрт ахаас минь хүссэнчлэн; мөн тэрээр та нарын оюуныг бэлтгэхээр зарим зүйлийг та нарт ярьсан билээ; тийм ээ, мөн тэрээр та нарыг итгэлд мөн тэвчээрт ухуулсан бөлгөө—
- 4 Тийм ээ, бүр та нар үгийг зүрх сэтгэлдээ тарихаар тийм их итгэлтэй байхад, та нар үүний сайныг нь туршин шалгаж болохын тулд буюу.
- 5 Мөн уг Бурханы Хүүд байдаг эсэх, эсвээс Христ байх эсэх нь та нарын оюунд их том асуулт болохыг бид ойлгов.
- 6 Мөн түүнчлэн авралд хүргэдэг үг Христэд буй гэдгийг ах маань та нарт олон жишээгээр нотолсныг та нар болгоов.
- 7 Бурханы Хүүгээр гэтэлгэл ирнэ гэсэн Зиносын үгсээс, мөн түүнчлэн Зинокийн үгсээс ах минь иш татав; мөн түүнчлэн тэрээр эдгээр зүйлийг үнэнийг нотлохоор Мосегийнхоос иш татсан болой.
- 8 Мөн эдүгээ, болгоогтун, эдгээр зүйлийн үнэнийг би өөрөө та нарт гэрчлэх болно. Болгоогтун, би та нарт хэлнэ, Христ хүмүүний үрсийн дунд өөрийн хүмүүсийн зөрчлүүдийг өөртөө авахын тулд ирэхийг, мөн тэр дэлхийн нүглийг цагаатгах болно гэдгийг би мэднэ; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан билээ.

## Alma 34

And now it came to pass that after Alma had spoken these words unto them he sat down upon the ground, and Amulek arose and began to teach them, saying:

My brethren, I think that it is impossible that ye should be ignorant of the things which have been spoken concerning the coming of Christ, who is taught by us to be the Son of God; yea, I know that these things were taught unto you bountifully before your dissension from among us.

And as ye have desired of my beloved brother that he should make known unto you what ye should do, because of your afflictions; and he hath spoken somewhat unto you to prepare your minds; yea, and he hath exhorted you unto faith and to patience—

Yea, even that ye would have so much faith as even to plant the word in your hearts, that ye may try the experiment of its goodness.

And we have beheld that the great question which is in your minds is whether the word be in the Son of God, or whether there shall be no Christ.

And ye also beheld that my brother has proved unto you, in many instances, that the word is in Christ unto salvation.

My brother has called upon the words of Zenos, that redemption cometh through the Son of God, and also upon the words of Zenock; and also he has appealed unto Moses, to prove that these things are true.

And now, behold, I will testify unto you of myself that these things are true. Behold, I say unto you, that I do know that Christ shall come among the children of men, to take upon him the transgressions of his people, and that he shall atone for the sins of the world; for the Lord God hath spoken it.

- 9 Учир нь цагаатгал хийгдэх нь зайлшгүй юм; учир нь Мөнхийн Бурханы агуу их төлөвлөгөөний дагуу цагаатгал хийгдэх ёстой, эс бөгөөс бүх хүн төрөлтөн гарцаагүй мөхөх ёстой; тийм ээ, бүгд хатуурсан; тийм ээ, бүгд унасан мөн төөрөлдсөн, мөн зайлшгүй хийгдэх ёстой уг цагаатгалаар бус аваас мөхөх ёстой.
- 10 Учир нь агуу их болоод эцсийн золиослол байх ёстой нь зайлшгүй; тийм ээ, хүмүүний золиослол бус, бас амьтных ч бус, бас ямар ч жигүүртнийх бус болой; учир нь энэ нь хүмүүний золиослол байхгүй; харин энэ нь хэмжээлшгүй хийгээд мөнхийн золиослол байх ёстой.
- 11 Эдүгээ өөр нэгний нүглийг цагаатган өөрийн цусыг золиосолж чадах ямар ч хүн үгүй. Эдүгээ, хэрэв хүмүүн аллага үйлдвэл, болгоогтун шударга болох манай хууль ахынх нь амийг авна гэж үү? Би та нарт хэлнэ, Үгүй.
- 12 Гэвч хууль алсан түүний амийг шаарддаг; тиймийн тул дэлхийн нүглүүдэд хангалттай байх тэр нь хэмжээлшгүй цагаатгалаас өөр юу ч байж эс чадах ажээ.
- 13 Тиймийн тул, агуу их болоод эцсийн золиослол байх нь зайлшгүй, мөн тэгээд цус урсгахыг зогсоох зүйл байх болно, өөрөөр хэлбэл энэ нь байвал зохино; чингээд Мосегийн хууль гүйцэлдэх болно; тийм ээ, энэ нь бүгд гүйцэлдэх болно, зураас мөн үсэг бүр, мөн юу ч өнгөрөөд л дуусахгүй болой.
- 14 Мөн болгоогтун, энэ нь хуулийн бүхэл утга, цэг болгон нь агуу их болоод эцсийн золиослолын зүг заадаг; мөн тэр агуу болоод эцсийн золиослол нь Бурханы Хүү байх болно, тийм ээ, хэмжээлшгүй бөгөөд үүрдийнх бөлгөө.
- 15 Мөн тийн тэрээр өөрийн нь нэрэнд итгэх тэд бүгдэд авралыг авчрах болно; шударга ёсыг давамгайлах тэр, мөн хүмүүнд, тэд наманчлалд итгэлтэй байх тэр замыг авчрах нигүүлслийн зүрх сэтгэлийг бий болгох нь эцсийн золиослолын зорилго юм.

For it is expedient that an atonement should be made; for according to the great plan of the Eternal God there must be an atonement made, or else all mankind must unavoidably perish; yea, all are hardened; yea, all are fallen and are lost, and must perish except it be through the atonement which it is expedient should be made.

For it is expedient that there should be a great and last sacrifice; yea, not a sacrifice of man, neither of beast, neither of any manner of fowl; for it shall not be a human sacrifice; but it must be an infinite and eternal sacrifice.

Now there is not any man that can sacrifice his own blood which will atone for the sins of another. Now, if a man murdereth, behold will our law, which is just, take the life of his brother? I say unto you, Nay.

But the law requireth the life of him who hath murdered; therefore there can be nothing which is short of an infinite atonement which will suffice for the sins of the world.

Therefore, it is expedient that there should be a great and last sacrifice, and then shall there be, or it is expedient there should be, a stop to the shedding of blood; then shall the law of Moses be fulfilled; yea, it shall be all fulfilled, every jot and tittle, and none shall have passed away.

And behold, this is the whole meaning of the law, every whit pointing to that great and last sacrifice; and that great and last sacrifice will be the Son of God, yea, infinite and eternal.

And thus he shall bring salvation to all those who shall believe on his name; this being the intent of this last sacrifice, to bring about the bowels of mercy, which overpowereth justice, and bringeth about means unto men that they may have faith unto repentance.

16 Мөн наманчлалд хүргэх итгэлийг бодитой болгоогүй нь шударга ёсны шаардлагын бүх л хуульд харьяалагдаж байхад нигүүлсэл нь тийншударга ёсны шаардлагыг хангаж, мөн тэднийг аюулгүйн гараар хүрээлж чадна; тиймийн тул зөвхөн наманчлалд хүргэх итгэлтэй түүнд агуу их хийгээд гэтэлгэлийн мөнхийн төлөвлөгөө түүнд үйлчилдэг.

17 Тиймийн тул ах дүүс минь, тэрээр та нарын дээр нигүүлсэнгүй байхын тулд, та нар түүний ариун нэрийг дуудаж эхлэхийн тулд, наманчлалд хүргэх итгэлийг бодитой болгон эхэлж болохыг Бурхан та нарт соёрхох болтугай.

18 Тийм ээ, нигүүлслийн тулд түүнээс гуйцгаа, учир нь тэр аврах хүчтэй билээ.

19 Тийм ээ, өөрсдийгөө даруу болго, мөн түүнд хандан залбирлаа үргэлжлүүлэгтүн.

20 Та нар талбайдаа байхдаа тийм ээ, түүнд хандан, өөрсдийн бүх мал сүргийнхээ төлөө залбиран гуй.

21 Гэртээ түүнд залбиран гуй, тийм ээ, бүх гэрийнхнийхээ төлөө, өглөө, өдөр мөн үдэш аль алинд нь буюу.

22 Тийм ээ, дайснуудынхаа хүчний эсрэг түүнээс залбиран гуй.

23 Тийм ээ, бүх зөв шударгын дайсан болох чөтгөрийн эсрэг түүнээс гуй.

24 Та нар түүгээр дэгжиж болохын тулд өөрсдийн талбай дахь ургацынхаа төлөө түүнээс гуй.

25 Тэдгээр нь өсөж үржихийн тулд төлөө гуй, талбай дахь сүргийнхээ.

26 Гэвч энэ нь бүгд бус; гонхнууддаа мөн нууц байрнууддаа, мөн аглаг буйддаа та нар өөрсдийн сүнсийг уудлан гаргах ёстой.

27 Тийм ээ, мөн та нар Их Эзэнээс гуйгаагүй үедээ ч, зүрх сэтгэл чинь дүүрэн байг, аз жаргалынхаа төлөө, мөн түүнчлэн та нарын эргэн тойронд байгаа тэдний аз жаргалын төлөө залбирлаа үргэлжлүүлэн түүнд хандуулж бай.

And thus mercy can satisfy the demands of justice, and encircles them in the arms of safety, while he that exercises no faith unto repentance is exposed to the whole law of the demands of justice; therefore only unto him that has faith unto repentance is brought about the great and eternal plan of redemption.

Therefore may God grant unto you, my brethren, that ye may begin to exercise your faith unto repentance, that ye begin to call upon his holy name, that he would have mercy upon you;

Yea, cry unto him for mercy; for he is mighty to save.

Yea, humble yourselves, and continue in prayer unto him.

Cry unto him when ye are in your fields, yea, over all your flocks.

Cry unto him in your houses, yea, over all your household, both morning, mid-day, and evening.

Yea, cry unto him against the power of your enemies.

Yea, cry unto him against the devil, who is an enemy to all righteousness.

Cry unto him over the crops of your fields, that ye may prosper in them.

Cry over the flocks of your fields, that they may increase.

But this is not all; ye must pour out your souls in your closets, and your secret places, and in your wilderness.

Yea, and when you do not cry unto the Lord, let your hearts be full, drawn out in prayer unto him continually for your welfare, and also for the welfare of those who are around you.



- 28 Мөн эдүгээ болгоогтун, хайрт ах дүүс минь, би та нарт хэлнэ, энэ нь бүгд хэмээн бүү бод; учир нь та нар эдгээр бүх зүйлийг хийсний дараа, хэрэв та нар гачигдсаныг, мөн нүцгэрснийг хоосон буцааж, мөн өвдсөн хийгээд зовсонд үл очин, мөн хэрэв та нарт буй аваас хөрөнгөнөөсөө гачигдсан тэдэнтэй эс хуваалцвал—Би та нарт хэлнэ, хэрэв та нар эдгээр зүйлийн нэгийг ч эс хийвээс, болгоогтун, залбирал тань хоосон, мөн та нарт ямар ч хэрэггүй байж, мөн та нар сүсэг бишрэлийг үгүйсгэсэн хоёр нүүртэн лугаа адил байх болно.
- 29 Тиймийн тул, хэрэв та нар энэрэнгүй байхыг санахгүй бол, та нар цэвэршүүлэгчдээр хаягддаг новш лугаа адил, (энэ нь ямар ч ашиггүй учир) хүмүүсийн хөл дор дэвслэгдэнэ.
- 30 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар ийм олон гэрчлэл хүлээн авсныхаа дараа, ариун судрууд эдгээр зүйлийг гэрчилдгийг мэдсэн учир, та нар ирж мөн наманчлалын үр шимийг авчраасай хэмээнэ би.
- 31 Тийм ээ, та нар ирж мөн зүрх сэтгэлээ цаашид бүү хатууруулаасай хэмээнэ би; учир нь болгоогтун, та нарын авралын өдөр мөн үе нь эдүгээ болой; мөн тиймийн тул, хэрэв та нар наманчилж зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, гэтэлгэлийн агуу их төлөвлөгөө тэр даруй та нарт үйлчлэх болно.
- 32 Учир нь болгоогтун, энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх үе; тийм ээ, болгоогтун энэ амьдралын өдөр бол хүмүүн өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр юм.
- 33 Мөн эдүгээ, та нарт миний урьд нь хэлсэнчлэн, та нарт ийм олон гэрчлэл байсан учир, тиймийн тул, эцсийг хүртэл наманчлалын өдрөө бүү хойшлуулаасай хэмээн би та нараас гуйна; учир нь мөнхийн тулд бэлтгэхээр бидэнд өгөгдсөн амьдралын энэ өдрийн дараа, болгоогтун, хэрэв бид энэ амьдралдаа цагийг сайнаар ашиглахгүй бол, тэгвэл ямар ч хөдөлмөр гүйцэлдэж чадахгүй шөнийн харанхуй ирэх болно.
- 34 Тэрхүү аймшигт хямралд авчрагдсан үедээ би наманчилна хэмээн, би Бурхандаа эргэж очих болно хэмээн та нар хэлж чадахгүй. Үгүй, та нар үүнийг хэлж чадахгүй; учир нь энэ амьдралаас гарах цагт та нарын биесийг эзэмдэж байдаг тэрхүү сүнс, мөнхүү тэр сүнс мөнхийн дэлхийд та нарын биесийг эзэмших хүчтэй байх болно.

And now behold, my beloved brethren, I say unto you, do not suppose that this is all; for after ye have done all these things, if ye turn away the needy, and the naked, and visit not the sick and afflicted, and impart of your substance, if ye have, to those who stand in need—I say unto you, if ye do not any of these things, behold, your prayer is vain, and availeth you nothing, and ye are as hypocrites who do deny the faith.

Therefore, if ye do not remember to be charitable, ye are as dross, which the refiners do cast out, (it being of no worth) and is trodden under foot of men.

And now, my brethren, I would that, after ye have received so many witnesses, seeing that the holy scriptures testify of these things, ye come forth and bring fruit unto repentance.

Yea, I would that ye would come forth and harden not your hearts any longer; for behold, now is the time and the day of your salvation; and therefore, if ye will repent and harden not your hearts, immediately shall the great plan of redemption be brought about unto you.

For behold, this life is the time for men to prepare to meet God; yea, behold the day of this life is the day for men to perform their labors.

And now, as I said unto you before, as ye have had so many witnesses, therefore, I beseech of you that ye do not procrastinate the day of your repentance until the end; for after this day of life, which is given us to prepare for eternity, behold, if we do not improve our time while in this life, then cometh the night of darkness wherein there can be no labor performed.

Ye cannot say, when ye are brought to that awful crisis, that I will repent, that I will return to my God. Nay, ye cannot say this; for that same spirit which doth possess your bodies at the time that ye go out of this life, that same spirit will have power to possess your body in that eternal world.

35 Учир нь болгоогтун, хэрэв та нар бүр үхлийг хүртэл наманчлалынхаа өдрийг хойшлуулсан бол, болгоогтун, та нар чөтгөрийн сүнсэнд харьяалагддаг болсон байна; мөн тэрээр та нарыг өөрийн хэмээн лацдах болно, тиймийн тул Их Эзэний Сүнс таныг орхин гарч, мөн таны дотор эзлэх зайгүй болж, мөн чөтгөр таны дээр бүх хүчийг эзэмших болно; мөн энэ нь ёс бусыг үйлдэгчдийн сүүлчийн байдал юм.

36 Мөн би үүнийг мэднэ, яагаад гэвэл Их Эзэн өөрөө ариун бус дуганд үл оршино, харин зөв шударгыг үйлдэгчдийн зүрх сэтгэлд тэрээр оршихыг хэлсэн буюу; тийм ээ, мөн тэрээр түүнчлэн зөв шударгыг үйлдэгчид дахин гадагш гарахгүйгээр түүний хаант улсад суух болно хэмээн хэлжээ; харин тэдний өмсгөл Хурганы цусаар цагаан болгогдох болно.

37 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, та нар эдгээр зүйлийг санаасай, мөн та нар Бурханы өмнө айдастайгаар өөрсдийн авралыг гүйцээгээсэй, мөн та нар Христийн ирэлтийг цаашид бүү үгүйсгээсэй хэмээн хүснэ би;

38 Та нар Ариун Сүнсний эсрэг цаашид бүү тэмцээсэй, харин та нар үүнийг хүлээн аваасай, мөн Христийн нэрийг өөрсөд дээрээ аваасай; та нар өөрсдийгөө бүр тоос шороо мэт даруусган, мөн байж болох газар бүрдээ Бурханыг сүнсэнд бас үнэнд шүтэн бишрээсэй; мөн та нарын дээр түүний бэлэглэдэг тэрхүү олон нигүүлсэл мөн адислалуудын төлөө та нар өдөр бүр талархалтайгаар амьдраасай.

39 Тийм ээ, мөн түүнчлэн би та нарт ухуулна, ах дүүс минь, та нар чөтгөрийн уруу таталгаар зайцуулагдан удирдагдахгүй байж болохын тулд, тэрээр та нарыг давамгайлахгүй байж болохын тулд, та нар эцсийн өдөр түүний хараат болохгүй байж болохын тулд та нар үргэлж залбирахаа анхаар; учир нь болгоогтун, тэрээр та нарыг ямар ч сайн зүйлээр эс шагнадаг билээ.

40 Мөн эдүгээ хайрт ах дүүс минь, тэвчээртэй байхыг, мөн та нар бүх зүйлийн зовлонгуудыг тэвчихийг; та нарыг үлэмж ядуугийн чинь учир зайлуулдаг тэднийг та нар тэдэнтэй адил нүгэлтнүүд болохгүйн тулд гадуурхахгүй байхыг би та нарт ухууль;

41 Харин та нар тэвчээртэй байж, мөн та нар нэгэн өдөр бүх зовлонгуудаасаа амарна гэсэн гуйвшгүй найдлагатайгаар тэдгээр зовлонг тэвчихийг буюу.

For behold, if ye have procrastinated the day of your repentance even until death, behold, ye have become subjected to the spirit of the devil, and he doth seal you his; therefore, the Spirit of the Lord hath withdrawn from you, and hath no place in you, and the devil hath all power over you; and this is the final state of the wicked.

And this I know, because the Lord hath said he dwelleth not in unholy temples, but in the hearts of the righteous doth he dwell; yea, and he has also said that the righteous shall sit down in his kingdom, to go no more out; but their garments should be made white through the blood of the Lamb.

And now, my beloved brethren, I desire that ye should remember these things, and that ye should work out your salvation with fear before God, and that ye should no more deny the coming of Christ;

That ye contend no more against the Holy Ghost, but that ye receive it, and take upon you the name of Christ; that ye humble yourselves even to the dust, and worship God, in whatsoever place ye may be in, in spirit and in truth; and that ye live in thanksgiving daily, for the many mercies and blessings which he doth bestow upon you.

Yea, and I also exhort you, my brethren, that ye be watchful unto prayer continually, that ye may not be led away by the temptations of the devil, that he may not overpower you, that ye may not become his subjects at the last day; for behold, he rewardeth you no good thing.

And now my beloved brethren, I would exhort you to have patience, and that ye bear with all manner of afflictions; that ye do not revile against those who do cast you out because of your exceeding poverty, lest ye become sinners like unto them;

But that ye have patience, and bear with those afflictions, with a firm hope that ye shall one day rest from all your afflictions.

## Алма 35

- 1 Эдүгээ улиран тохиох дор Амюлек эдгээр үгсээ төгсгөл болгосны дараа, тэд өөрсдөө цугласан олны дундаас гарч мөн Жершоны нутагт ирэв.
- 2 Тийм ээ, мөн ах дүүсийн үлдсэн нь, зорамчуудад үгийг номлосныхоо дараа, түүнчлэн Жершоны нутагт ирэв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор зорамчуудын илүү нэр хүндтэй хэсэг өөрсдөд нь номлогдсон үгсийн талаар хамтдаа зөвлөлдсөнийхөө дараа, тэд үгийн учир ууртай байв, учир нь энэ нь тэдний башир аргыг устгасан ажээ; тиймийн тул тэд үгсийг анхааран сонсмооргүй байсан аж.
- 4 Мөн тэд илгээж мөн бүх нутаг даяар бүх хүмүүсийг нэгтгэн цуглуулж, мөн яригдсан үгсийн талаар тэдэнтэй зөвлөлдөв.
- 5 Эдүгээ тэдний захирагчид мөн тэдний санваартнууд хийгээд тэдний багш нар өөрсдийнхөө хүслийн талаар хүмүүст мэдүүлсэнгүй; тиймийн тул тэд нууцаар бүх хүмүүсийн бодлыг олж мэдэв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэд бүх хүмүүсийн бодлыг олж мэдсэний дараа, Алма болон түүний ах дүүсээр яригдсан үгсэд таалалтай байсан тэд уг нутгаас зайлуулагдав; мөн тэд олон байв; мөн тэд түүнчлэн Жершоны нутагт ирэв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Алма болон түүний ах дүүс тэдэнд тохинуулав.
- 8 Эдүгээ зорамчуудын хүмүүс Жершонд байсан Аммоны хүмүүст уурлаж, мөн зорамчуудын ерөнхий захирагч машид ёс бус хүн байсан учир, тэдний нутагт очсон тэднийг бүгдийг нутгаасаа хөөж гаргахыг хүсэж Аммоны хүмүүст илгээв.
- 9 Мөн тэрээр тэднийг олон заналхийллээр сүрдүүлж байв. Мөн эдүгээ Аммоны хүмүүс тэдний үгсээс айсангүй; тиймийн тул тэд тэднийг хөөж гаргасангүй, харин тэд өөрсдөд нь ирсэн зорамчуудын бүх ядуусыг хүлээн авав; мөн тэд тэднийг асарч, мөн тэднийг хувцаслаж, мөн тэдэнд өвлөх нутгуудыг өгөв; мөн тэд өөрсдийн нь хүслийн дагуу тэдэнд туслах болгов.

## Alma 35

Now it came to pass that after Amulek had made an end of these words, they withdrew themselves from the multitude and came over into the land of Jershon.

Yea, and the rest of the brethren, after they had preached the word unto the Zoramites, also came over into the land of Jershon.

And it came to pass that after the more popular part of the Zoramites had consulted together concerning the words which had been preached unto them, they were angry because of the word, for it did destroy their craft; therefore they would not hearken unto the words.

And they sent and gathered together throughout all the land all the people, and consulted with them concerning the words which had been spoken.

Now their rulers and their priests and their teachers did not let the people know concerning their desires; therefore they found out privily the minds of all the people.

And it came to pass that after they had found out the minds of all the people, those who were in favor of the words which had been spoken by Alma and his brethren were cast out of the land; and they were many; and they came over also into the land of Jershon.

And it came to pass that Alma and his brethren did minister unto them.

Now the people of the Zoramites were angry with the people of Ammon who were in Jershon, and the chief ruler of the Zoramites, being a very wicked man, sent over unto the people of Ammon desiring them that they should cast out of their land all those who came over from them into their land.

And he breathed out many threatenings against them. And now the people of Ammon did not fear their words; therefore they did not cast them out, but they did receive all the poor of the Zoramites that came over unto them; and they did nourish them, and did clothe them, and did give unto them lands for their inheritance; and they did administer unto them according to their wants.

10 Эдүгээ энэ нь зорамчуудыг Аммоны хүмүүсийн эсрэг уурлахад өдөөн хатгаж, мөн тэд леменчүүдтэй хутгалдан мөн тэднийг түүнчлэн тэдний эсрэг өдөөн хатгаж эхлэв.

11 Мөн тийн зорамчууд мөн леменчүүд Аммоны хүмүүсийн эсрэг, мөн түүнчлэн нифайчуудын эсрэг дайны бэлтгэлүүдийг хийж эхлэв.

12 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван долоо дахь он төгсөв.

13 Мөн Аммоны хүмүүс Жершоны нутгаас гарч одон, мөн Мелекийн нутагт ирж, мөн Жершоны нутагт, тэдгээр нь леменчүүдийн их цэрэгтэй мөн зорамчуудын их цэрэгтэй тэмцэлдэж болохын тулд нифайчуудын их цэрэгт зай тавьж өгөв; мөн тийн шүүгчдийн засаглалын арван найм дахь онд леменчүүд хийгээд нифайчуудын дунд дайн эхлэв; мөн тэдний дайнуудын цэдэг хожим өгөгдөх болно.

14 Мөн Алма, мөн Аммон болон тэдний ах дүүс, мөн түүнчлэн Алмагийн хоёр хүү, олон зорамчуудыг наманчлалд авчрахад Бурханы мутарт зэмсэг болж байсныхаа дараа Зарахемла нутагт эргэж ирэв; мөн наманчлалд авчрагдсан болгон нутгаасаа хөөгдөв; гэвч тэд Жершоны нутагт өвлөх нутагтай болж мөн тэд өөрсдийгөө, мөн эхнэр, мөн хүүхдүүд, мөн нутгаа өмгөөлөхөөр зэвсгээ агсацгаасан байв.

15 Эдүгээ Алма, өөрийн хүмүүсийн алдсын төлөө гашуудан байсан учир нь, тийм ээ, тэдний дунд байсан тэр дайнуудын, мөн цус урсгалтын, мөн зөрчилдөөнүүдийн улмаас болой; хот болгонд бүх хүмүүсийн дунд үгийг тунхаглаж байв, өөрөөр хэлбэл мөн үгийг тунхаглахаар илгээгдсэн учир; мөн хүмүүсийн зүрх сэтгэл хатуурч эхэлснийг, мөн үгийн чандын учир тэд гомдож эхэлснийг харсан учир, түүний зүрх сэтгэл үлэмж харамсаж байв.

16 Тиймийн тул, тэрээр тэдэнд тус тусад нь, зөв шударгад хамаарах зүйлүүдийн талаар өөрийн захиасыг өгч болохын тулд хөвгүүдээ цугларах болгов. Мөн тэдэнд өгсөн зарлигуудынх нь шастир түүний өөрийнх нь цэдгийн дагуу бидэнд байгаа болно.

Now this did stir up the Zoramites to anger against the people of Ammon, and they began to mix with the Lamanites and to stir them up also to anger against them.

And thus the Zoramites and the Lamanites began to make preparations for war against the people of Ammon, and also against the Nephites.

And thus ended the seventeenth year of the reign of the judges over the people of Nephi.

And the people of Ammon departed out of the land of Jershon, and came over into the land of Melek, and gave place in the land of Jershon for the armies of the Nephites, that they might contend with the armies of the Lamanites and the armies of the Zoramites; and thus commenced a war betwixt the Lamanites and the Nephites, in the eighteenth year of the reign of the judges; and an account shall be given of their wars hereafter.

And Alma, and Ammon, and their brethren, and also the two sons of Alma returned to the land of Zarahemla, after having been instruments in the hands of God of bringing many of the Zoramites to repentance; and as many as were brought to repentance were driven out of their land; but they have lands for their inheritance in the land of Jershon, and they have taken up arms to defend themselves, and their wives, and children, and their lands.

Now Alma, being grieved for the iniquity of his people, yea for the wars, and the bloodsheds, and the contentions which were among them; and having been to declare the word, or sent to declare the word, among all the people in every city; and seeing that the hearts of the people began to wax hard, and that they began to be offended because of the strictness of the word, his heart was exceedingly sorrowful.

Therefore, he caused that his sons should be gathered together, that he might give unto them every one his charge, separately, concerning the things pertaining unto righteousness. And we have an account of his commandments, which he gave unto them according to his own record.

## Алма 36

- 1 Хүү минь, миний үгсэд чих тавин сонс; учир нь та нар Бурханы зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно хэмээн би чамд тангараглаж байна.
- 2 Эцэг өвгөдийнхөө боолчлолыг санахдаа миний хийснийг чамайг хийгээсэй хэмээнэ би, учир нь тэд дарангуйлалд байлаа, мөн Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханаас өөр хэн ч тэднийг чөлөөлж чадахгүй байв; мөн тэрээр тэднийг зовлонгуудаас нь лавтайяа чөлөөлсөн бөлгөө.
- 3 Мөн эдүгээ, Ай Хиламан хүү минь, болгоогтун, чи залуугаараа байна, мөн тиймийн тул, би чамайг үгсийг минь сонсож мөн надаас сураасай хэмээн чамаас хүсэж байна; учир нь Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд хийгээд өөрсдийн зовлонгуудад дэмжигдэх болно, мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг би мэднэ.
- 4 Мөн би өөрөөрөө мэднэ гэж чамайг бүү бодоосой хэмээнэ би—биеийнхээр бус харин сүнснийхээр, эгэл оюунаар бус харин Бурханаар бөлгөө.
- 5 Эдүгээ, болгоогтун, би чамд хэлнэ, хэрэв би Бурханаар төрөөгүй сэн бол би эдгээр зүйлийг мэдэхгүй байсан; гэвч Бурхан ариун тэнгэр элчийнхээ амаар эдгээр зүйлийг надад мэдүүлсэн юм, өөрийн минь зохистойн учир бус болой;
- 6 Учир нь би Мозаягийн хөвгүүдтэй, Бурханы сүмийг устгахыг эрэлхийлсээр явж байсан; гэвч болгоогтун, Бурхан биднийг замд нь зогсоохоор ариун тэнгэр элчээ илгээсэн юм.
- 7 Мөн болгоогтун, тэрээр бидэнд аянгын дуу хоолойгоор мэт ярьж, мөн бидний хөл доорх бүх л дэлхий чичирсэн билээ; мөн бид бүгд газарт унав, учир нь Их Эзэнээс айх айдас бидний дээр ирэв.
- 8 Гэвч болгоогтун, уг дуу хоолой надад хэлэв: Босогтун. Мөн би босож мөн зогсоод, мөн нэгэн тэнгэр элчийг болгоов.

## Alma 36

My son, give ear to my words; for I swear unto you, that inasmuch as ye shall keep the commandments of God ye shall prosper in the land.

I would that ye should do as I have done, in remembering the captivity of our fathers; for they were in bondage, and none could deliver them except it was the God of Abraham, and the God of Isaac, and the God of Jacob; and he surely did deliver them in their afflictions.

And now, O my son Helaman, behold, thou art in thy youth, and therefore, I beseech of thee that thou wilt hear my words and learn of me; for I do know that whosoever shall put their trust in God shall be supported in their trials, and their troubles, and their afflictions, and shall be lifted up at the last day.

And I would not that ye think that I know of myself—not of the temporal but of the spiritual, not of the carnal mind but of God.

Now, behold, I say unto you, if I had not been born of God I should not have known these things; but God has, by the mouth of his holy angel, made these things known unto me, not of any worthiness of myself;

For I went about with the sons of Mosiah, seeking to destroy the church of God; but behold, God sent his holy angel to stop us by the way.

And behold, he spake unto us, as it were the voice of thunder, and the whole earth did tremble beneath our feet; and we all fell to the earth, for the fear of the Lord came upon us.

But behold, the voice said unto me: Arise. And I arose and stood up, and beheld the angel.

- 9 Мөн тэрээр надад хэлэв: Та өөрийгөө устгуулахыг хүслээ ч, Бурханы сүмийн устгалыг цаашид бүү эрэлхийл.
- 10 Мөнхүү улиран тохиох дор би газарт унав; мөн гурван өдөр бас гурван шөнийн турш би амаа нээж ч, бас үе мөчөө хөдөлгөж ч чадсангүй.
- 11 Мөн уг тэнгэр элч надад ах дүүсийн минь сонссон тэрхүү илүү зүйлийг ярив, гэвч би тэдгээрийг сонссонгүй; учир нь би—та өөрийгөө устгуулахыг хүслээ ч Бурханы сүмийн устгалыг цаашид бүү эрэлхийл—гэсэн үгсийг дуулаад би магад устгагдах болов уу хэмээн, бүр тийм их айдас мөн гайхашралдаа цочирдсоноос би газарт унаж мөн цаашид юу ч сонссонгүй.
- 12 Гэвч би мөнхийн зовлонд тамлагдаж байлаа, учир нь бодгаль минь хамгийн их хэмжээгээр тарчлагдаж мөн өөрийн бүх нүглүүдээр тамлагдав.
- 13 Тийм ээ, би өөрийн бүх нүглүүд мөн алдсуудыг санаж байв, үүний учир би тамын өвдөлтөөр тарчлагдаж байлаа; тийм ээ, би Бурханыхаа эсрэг тэмцсэнээ, мөн би түүний ариун зарлигуудыг дагаагүйгээ ойлгосон юм.
- 14 Тийм ээ, мөн би түүний хүүхдүүдээс олныг нь хөнөөсөн, өөрөөр хэлбэл устгал уруу тэднийг удирдсан болой; тийм ээ, мөн эцэст нь, Бурханыхаа дэргэд ирнэ гэдэг тэр л бодол бодгалийг минь илэрхийлэхийн аргагүй аймшигтайгаар тарчилгахаар миний алдсууд ийм агуу байв.
- 15 Ай, би бодов, би цөлөгдөж мөн сүнсээр мөн биеэрээ ч үл орших болж чаддаг болоосой, би үйлсээрээ шүүгдэхээр, Бурханыхаа дэргэд зогсохоор аваагчид дахгүй байж болохын тулд.
- 16 Мөн эдүгээ, гурван өдөр мөн гурван шөнийн турш, бүр ялагдсан бодгалийн өвдөлтөөр би тарчлав.
- 17 Мөнхүү улиран тохиох дор би тийн зовлонд тамлагдаж, өөрийн олон нүглийн дурсамжиндаа тарчлагдаж байхдаа би, болгоогтун, би түүнчлэн дэлхийн нүглүүдийг цагаатгахаар, Бурханы Хүү, Есүс Христ гэгч нэгний ирэлтийн талаар хүмүүст эцгийнхээ бошиглохыг дуулснаа санав.

And he said unto me: If thou wilt of thyself be destroyed, seek no more to destroy the church of God.

And it came to pass that I fell to the earth; and it was for the space of three days and three nights that I could not open my mouth, neither had I the use of my limbs.

And the angel spake more things unto me, which were heard by my brethren, but I did not hear them; for when I heard the words—If thou wilt be destroyed of thyself, seek no more to destroy the church of God—I was struck with such great fear and amazement lest perhaps I should be destroyed, that I fell to the earth and I did hear no more.

But I was racked with eternal torment, for my soul was harrowed up to the greatest degree and racked with all my sins.

Yea, I did remember all my sins and iniquities, for which I was tormented with the pains of hell; yea, I saw that I had rebelled against my God, and that I had not kept his holy commandments.

Yea, and I had murdered many of his children, or rather led them away unto destruction; yea, and in fine so great had been my iniquities, that the very thought of coming into the presence of my God did rack my soul with inexpressible horror.

Oh, thought I, that I could be banished and become extinct both soul and body, that I might not be brought to stand in the presence of my God, to be judged of my deeds.

And now, for three days and for three nights was I racked, even with the pains of a damned soul.

And it came to pass that as I was thus racked with torment, while I was harrowed up by the memory of my many sins, behold, I remembered also to have heard my father prophesy unto the people concerning the coming of one Jesus Christ, a Son of God, to atone for the sins of the world.

18 Эдүгээ, миний оюун энэ бодол дээр тогтож тунгаах зуур, би зүрх сэтгэлдээ хашгирч: Ай Есүс, Бурханы Хүү та, шаналлын гүнд буй, мөн үүрдийн үхлийн гинжээр ороогдсон намайг нигүүлсээч гэв.

19 Мөн эдүгээ, болгоогтун, би үүнийг бодмогц, би өвчнөө цаашид санаж чадсангүй; тийм ээ, би нүглүүдийнхээ санамжинд цаашид тарчлагдахгүй болов.

20 Мөн ай ямар баясал, мөн ямар гайхамшигт гэрлийг болгоосон билээ би; тийм ээ, бодгаль минь ямархуу шаналалд байсан лугаа адил тийм үлэмжийн баяслаар дүүргэгдсэн байв!

21 Тийм ээ, би чамд хэлнэ, хүү минь, миний шаналал шиг тийм хурц мөн ийм гашуун нь байх аргагүй биз ээ. Тийм ээ, мөн дахин би чамд хэлнэ, хүү минь, нөгөө талаасаа бол миний баясал шиг ийм хурц бас амтлаг юм юу ч байж чадахгүй биз ээ.

22 Тийм ээ, Бурхан сэнтий дээрээ Бурханаа магтан дуулах байдалтай тоо томшгүй олон тэнгэр элчээр хүрээлүүлэн сууж байхыг бүр бидний эцэг Лихай үзсэний адил би харсан хэмээн бодсон; тийм ээ, мөн бодгаль минь тэнд байхаар тэмүүлсэн бөлгөө.

23 Гэвч болгоогтун, миний үе мөчүүд дахин хүчээ олж, мөн би хөл дээрээ босож, мөн би Бурханаар төрлөө гэдгээ хүмүүст мэдүүлэв.

24 Тийм ээ, мөн тэр цагаас бүр одоог хүртэл, би бодгалиудыг наманчлалд авчирч болохын тул; өөрийн амталсан тэр үлэмжийн баяслаас амтлахад тэднийг авчирч болохын тул; тэд түүнчлэн Бурханаар төрж, мөн Ариун Сүнсээр дүүргэгдэж болохын тул зогсолтгүйгээр хөдөлмөрлөсөөр ирсэн билээ.

25 Тийм ээ, мөн эдүгээ болгоогтун, Ай хүү минь, Их Эзэн хөдөлмөрийн минь үр шимд үлэмжийн агуу баяслыг надад өгдөг билээ;

26 Учир нь түүний надад мэдүүлсэн тэрхүү үгийн учир, болгоогтун, олон нь Бурханаар төрж, мөн миний амталсныг амталсан, мөн миний үзсэнийг нүдээрээ үзэв; тиймийн тул тэд миний ярьсан эдгээр зүйлийг миний мэддэгийн адил мэддэг бөлгөө; мөн надад буй мэдлэг бол Бурханаас юм.

Now, as my mind caught hold upon this thought, I cried within my heart: O Jesus, thou Son of God, have mercy on me, who am in the gall of bitterness, and am encircled about by the everlasting chains of death.

And now, behold, when I thought this, I could remember my pains no more; yea, I was harrowed up by the memory of my sins no more.

And oh, what joy, and what marvelous light I did behold; yea, my soul was filled with joy as exceeding as was my pain!

Yea, I say unto you, my son, that there could be nothing so exquisite and so bitter as were my pains. Yea, and again I say unto you, my son, that on the other hand, there can be nothing so exquisite and sweet as was my joy.

Yea, methought I saw, even as our father Lehi saw, God sitting upon his throne, surrounded with numberless concourses of angels, in the attitude of singing and praising their God; yea, and my soul did long to be there.

But behold, my limbs did receive their strength again, and I stood upon my feet, and did manifest unto the people that I had been born of God.

Yea, and from that time even until now, I have labored without ceasing, that I might bring souls unto repentance; that I might bring them to taste of the exceeding joy of which I did taste; that they might also be born of God, and be filled with the Holy Ghost.

Yea, and now behold, O my son, the Lord doth give me exceedingly great joy in the fruit of my labors;

For because of the word which he has imparted unto me, behold, many have been born of God, and have tasted as I have tasted, and have seen eye to eye as I have seen; therefore they do know of these things of which I have spoken, as I do know; and the knowledge which I have is of God.

27 Мөн би зүйл бүрийн зүдгүүр хийгээд бэрхшээлүүдийн доор, тийм ээ, мөн төрөл бүрийн зовлонгуудад дэмжигдсэн буюу; тийм ээ, Бурхан намайг шоронгоос, мөн хүлээснээс, мөн үхлээс чөлөөлсөн бөлгөө; тийм ээ, мөн би түүнд найдлага тавьдаг, мөн тэрээр намайг чөлөөлсөөр байх болно.

28 Мөн тэр эцсийн өдөр намайг өөртэйгөө хамт алдар сууд оршихоор өргөх болно гэдгийг би мэднэ; тийм ээ, мөн би түүнийг үүрд магтах болно, учир нь тэрээр бидний эцэг өвгөдийг Египетээс гарган авчирч, мөн тэрээр египетчүүдийг Улаан Тэнгист залгиулсан билээ; мөн тэрээр тэднийг өөрийн хүчээр амлагдсан нутагт орох хүртэл удирдсан билээ; тийм ээ, мөн тэрээр тэднийг цагаас цагт дарангуйллаас мөн боолчлолоос чөлөөлөн гаргасаар байсан шүү дээ.

29 Тийм ээ, мөн түүнчлэн тэрээр бидний эцэг өвгөдийг Иерусалим нутгаас гарган авчирсан; мөн түүнчлэн тэрээр, өөрийн үүрдийн хүчээр, тэднийг дарангуйллаас мөн боолчлолоос цагаас цагт бүр эдүгээ өдрийг хүртэл чөлөөлсөөр ирсэн; мөн би тэдний боолчлолыг санаандаа үргэлж хадгалсаар байдаг; тийм ээ, мөн түүнчлэн та нар миний адилаар, тэдний боолчлолыг санаандаа хадгалж байвал зохино.

30 Гэвч болгоогтун, хүү минь, энэ нь бүгд бус; учир нь та нар миний мэдэж байгааг, Бурханы зарлигуудыг дагахын хэрээр та нар нутагтаа дэгжих болно гэдгийг мэдвэл зохино; мөн та нар түүнчлэн, та нар Бурханы зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно гэдгийг мэдвэл зохино. Эдүгээ энэ нь түүний үгийн дагуу билээ.

And I have been supported under trials and troubles of every kind, yea, and in all manner of afflictions; yea, God has delivered me from prison, and from bonds, and from death; yea, and I do put my trust in him, and he will still deliver me.

And I know that he will raise me up at the last day, to dwell with him in glory; yea, and I will praise him forever, for he has brought our fathers out of Egypt, and he has swallowed up the Egyptians in the Red Sea; and he led them by his power into the promised land; yea, and he has delivered them out of bondage and captivity from time to time.

Yea, and he has also brought our fathers out of the land of Jerusalem; and he has also, by his everlasting power, delivered them out of bondage and captivity, from time to time even down to the present day; and I have always retained in remembrance their captivity; yea, and ye also ought to retain in remembrance, as I have done, their captivity.

But behold, my son, this is not all; for ye ought to know as I do know, that inasmuch as ye shall keep the commandments of God ye shall prosper in the land; and ye ought to know also, that inasmuch as ye will not keep the commandments of God ye shall be cut off from his presence. Now this is according to his word.



## Алма 37

- 1 Мөн эдүгээ, Хиламан хүү минь, надад итгэмжлэгдсэн цэдгүүдийг чамайг авахыг би чамд тушааж байна;
- 2 Мөн түүнчлэн энэ хүмүүсийн цэдгийг миний хийсний адилаар, Нифайн ялтсууд дээр хөтлөхийг, бүр би тэдгээрийг хадгалсны адил мөн миний хадгалсан эдгээр бүх зүйлийг эрхэмлэн хадгалахыг би чамд тушааж байна; учир нь тэдгээрийн хадгалагдаг нь мэргэн зорилгын тулд болой.
- 3 Мөн бүр эхлэлээс бидний өвөг дээдсийн удмын бичгийг агуулдаг, дээр нь ариун судруудын цэдгүүд байдаг, эдгээр сийлбэрүүдийг тээдэг эдгээр гуулин ялтсуудыг—
- 4 Болгоогтун, тэдгээр нь хадгалагдаж мөн нэг үеэс нөгөөд гардуулагдан, тэдгээрт тээгдсэн нууцуудыг тэд мэдэж болохын тулд, тэдгээр нь үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүс болгонд очих хүртэл Их Эзэний мутраар хадгалагдаж мөн хамгаалагдах нь бидний эцэг өвгөдөөр бошиглогдсон буюу.
- 5 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв тэдгээр нь хадгалагдах аваас гялалзсан өнгөтэй хэвээр байх ёстой; тийм ээ, мөн тэдгээр нь гялалзсан өнгөтэй хэвээр байх болно; тийм ээ, мөн ариун бичиг болох түүнийг тэсэн тэр бүх ялтсууд түүнчлэн тийм байх болно.
- 6 Эдүгээ энэ нь миний хувьд мунхаглал хэмээн чи бодож болно; гэвч болгоогтун, өчүүхэн мөн энгийн зүйлүүдээр агуу их зүйлүүд улиран авчрагддагийг би чамд хэлнэ; мөн өчүүхэн зүйлүүд олон тохиолдолд мэргэдийг гутаадаг бөлгөө.
- 7 Мөн Их Эзэн Бурхан өөрийн агуу хийгээд мөнхийн зорилгуудыг тохиолдуулах аргаар ажилладаг; мөн маш өчүүхэн аргаар Их Эзэн мэргэдийг ичээж мөн олон бодгалийн авралыг авчирдаг.
- 8 Мөн эдүгээ, эдгээр зүйл одоог хүртэл хамгаалагдан үлдсэн байх нь Бурханы мэргэн ухаан билээ; учир нь болгоогтун, тэдгээр нь энэ хүмүүсийн ой ухааныг тэлж, тийм ээ, мөн тэдний олонд замуудынх нь алдааг ойлгуулж; мөн тэднийг бодгалийнх нь авралд хүргэхээр Бурханых нь мэдлэгт авчирсаар ирсэн юм.

## Alma 37

And now, my son Helaman, I command you that ye take the records which have been entrusted with me;

And I also command you that ye keep a record of this people, according as I have done, upon the plates of Nephi, and keep all these things sacred which I have kept, even as I have kept them; for it is for a wise purpose that they are kept.

And these plates of brass, which contain these engravings, which have the records of the holy scriptures upon them, which have the genealogy of our forefathers, even from the beginning—

Behold, it has been prophesied by our fathers, that they should be kept and handed down from one generation to another, and be kept and preserved by the hand of the Lord until they should go forth unto every nation, kindred, tongue, and people, that they shall know of the mysteries contained thereon.

And now behold, if they are kept they must retain their brightness; yea, and they will retain their brightness; yea, and also shall all the plates which do contain that which is holy writ.

Now ye may suppose that this is foolishness in me; but behold I say unto you, that by small and simple things are great things brought to pass; and small means in many instances doth confound the wise.

And the Lord God doth work by means to bring about his great and eternal purposes; and by very small means the Lord doth confound the wise and bringeth about the salvation of many souls.

And now, it has hitherto been wisdom in God that these things should be preserved; for behold, they have enlarged the memory of this people, yea, and convinced many of the error of their ways, and brought them to the knowledge of their God unto the salvation of their souls.

- 9 Тийм ээ, би чамд хэлнэ, эдгээр ялтсууд дээрх, эдгээр цэдгүүдийг тээсэн, энэ зүйлүүд үгүй аваас, Аммон болон түүний ах дүүс тийм олон мянган леменчүүдэд тэдний эцэг өвгөдийн зөв бус уламжлалын талаар үнэмшүүлж чадахгүй байсан; тийм ээ, эдгээр цэдгүүд мөн үгс нь тэднийг наманчлалд авчирсан ажгуу; тэдгээр нь тэднийг Их Эзэн Бурханых нь мэдлэгт мөн Есүс Христ өөрсдийн Гэтэлгэгчдээ баясахад тэднийг хүргэсэн болой.
- 10 Мөн тэдний олон мянгыг нь, тийм ээ, мөн зүрх сэтгэлээ нүгэлд мөн алдсуудад эдүгээ хатууруулаад буй тэд бидний зөрүүд ах дүүс нифайчуудаас түүнчлэн олон мянгыг нь тэдний Гэтэлгэгчийн тухай мэдлэгт авчрахад тэдгээр нь хэрэгсэл болох эсэхийг хэн мэдэх билээ
- 11 Эдүгээ эдгээр нууцууд надад хараахан бүрэн дүүрэн мэдүүлэгдээгүй байна; тиймийн тул би түдгэлзэх болно.
- 12 Мөн хэрэв тэдгээр нь Бурханы мэдэх тэрхүү зорилго болох мэргэн зорилгын тулд хадгалагдан үлдсэнийг би хэлбэл хангалттай байх; учир нь тэрээр өөрийн бүх бүтээлүүддээ мэргэн ухаанаар зөвлөдөг, мөн түүний замууд шулуун, мөн түүний замнал нь нэгэн мөнхийн эргэлт авай.
- 13 Ай Хиламан хүү минь, Бурханы зарлигууд ямар чанд болохыг санагтун, санагтун. Мөн тэрээр хэлсэн нь: Хэрэв та нар миний зарлигуудыг дагавал та нар уг нутагт дэгжих болно—харин хэрэв та нар түүний зарлигуудыг дагахгүй аваас та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно.
- 14 Мөн эдүгээ, ариун нандин агаад, түүний нандин хадгалсаар ирсэн, мөн түүнчлэн тэрээр ирээдүйн үеийнхэнд өөрийнхөө хүчийг үзүүлж болохын тулд, тэрээр өөрийн мэргэн зорилгын тулд хадгалж мөн хамгаалсаар байх эдгээр зүйлийг Бурхан чамд даатгасныг санагтун, хүү минь.
- 15 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв чи Бурханы зарлигийг зөрчих аваас, болгоогтун, ариун нандин эдгээр зүйл чамаас Бурханы хүчээр хураагдаж, мөн Сатан чамайг будааны хальс мэт салхинд хийсгэж болохын тулд чи түүнд хүргэгдэх болно гэдгийг бошиглолын суу билгээр би чамд хэлнэ.

Yea, I say unto you, were it not for these things that these records do contain, which are on these plates, Ammon and his brethren could not have convinced so many thousands of the Lamanites of the incorrect tradition of their fathers; yea, these records and their words brought them unto repentance; that is, they brought them to the knowledge of the Lord their God, and to rejoice in Jesus Christ their Redeemer.

And who knoweth but what they will be the means of bringing many thousands of them, yea, and also many thousands of our stiffnecked brethren, the Nephites, who are now hardening their hearts in sin and iniquities, to the knowledge of their Redeemer?

Now these mysteries are not yet fully made known unto me; therefore I shall forbear.

And it may suffice if I only say they are preserved for a wise purpose, which purpose is known unto God; for he doth counsel in wisdom over all his works, and his paths are straight, and his course is one eternal round.

O remember, remember, my son Helaman, how strict are the commandments of God. And he said: If ye will keep my commandments ye shall prosper in the land—but if ye keep not his commandments ye shall be cut off from his presence.

And now remember, my son, that God has entrusted you with these things, which are sacred, which he has kept sacred, and also which he will keep and preserve for a wise purpose in him, that he may show forth his power unto future generations.

And now behold, I tell you by the spirit of prophecy, that if ye transgress the commandments of God, behold, these things which are sacred shall be taken away from you by the power of God, and ye shall be delivered up unto Satan, that he may sift you as chaff before the wind.

- 16 Гэвч хэрэв чи Бурханы зарлигуудыг дагаж, мөн ариун нандин эдгээр зүйлүүдээр Их Эзэн чамд зарлигласны дагуу хийх аваас, (учир нь чи тэдгээрээр юу хийх ёстой тэр бүх зүйлийн төлөө Их Эзэнд хандах ёстой) болгоогтун, газрын эсвээс тамын ямар ч хүч тэднийг чамаас салган авч чадахгүй, учир нь Бурхан өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлэхээр хүчирхэг бөлгөө.
- 17 Учир нь тэрээр чамд өгөх тэр бүх амлалтуудаа гүйцэлдүүлэх болно, учир нь тэрээр бидний эцэг өвгөдөд өгсөн амлалтуудаа гүйцэлдүүлсэн билээ.
- 18 Учир нь тэрээр өөрийн хүчийг ирээдүйн үеийнхэнд үзүүлж болохын тулд, өөрт буй мэргэн зорилгын улмаас эдгээр зүйлийг хадгалан үлдээнэ гэдгийг тэдэнд амласан болой.
- 19 Мөн эдүгээ болгоогтун, бүр леменчүүдээс олон мянгыг нь үнэний мэдлэгт сэргээхэд тэрбээр нэгэн зорилгоо гүйцэлдүүлсэн билээ; мөн тэрээр тэднээр өөрийн хүчийг үзүүлж, мөн түүнчлэн тэрээр тэднээр өөрийн хүчийг ирээдүйн үеийнхэнд ч бас үзүүлэх болно; тиймийн тул тэдгээр нь хадгалагдан үлдэх болно.
- 20 Тиймийн тул би чамд зарлиглана, Хиламан хүү минь, миний бүх үгсийг гүйцэлдүүлэхдээ хичээнгүй бай, мөн тэдгээрийн бичигдсэний дагуу Бурханы зарлигуудыг дагахдаа чи хичээнгүй бай.
- 21 Мөн эдүгээ, би чамд тэдгээр хорин дөрвөн ялтсын талаар ярья, нууцууд хийгээд харанхуйн ажлууд, мөн тэдний нууц ажлууд, өөрөөр хэлбэл устгагдсан тэдгээр хүмүүсийн нууц ажлуудыг энэ хүмүүст мэдүүлж болохын тулд чи тэдгээрийг хадгалах болно; тийм ээ, тэдний бүх аллага, мөн дээрэм, мөн тонуулууд хийгээд тэдний бүх ёсон бус мөн жигшүүрт хэргүүд энэ хүмүүст мэдүүлэгдэж болохын учир; тийм ээ, мөн чи эдгээр хөрвүүлэгчдийг хадгалан үлдээж болохын тулд бөлгөө.
- 22 Учир нь болгоогтун, Их Эзэн өөрийнх нь хүмүүс харанхуйд үйлдэхийг, тийм ээ, нууц аллага, мөн жигшүүрт хэргүүдийг үйлдэж эхлэхийг харсан билээ; тиймийн тул, хэрэв тэд наманчлахгүй аваас тэд газрын гадаргуугаас устгагдах болно хэмээн Их Эзэн хэлсэн юм.

But if ye keep the commandments of God, and do with these things which are sacred according to that which the Lord doth command you, (for ye must appeal unto the Lord for all things whatsoever ye must do with them) behold, no power of earth or hell can take them from you, for God is powerful to the fulfilling of all his words.

For he will fulfil all his promises which he shall make unto you, for he has fulfilled his promises which he has made unto our fathers.

For he promised unto them that he would preserve these things for a wise purpose in him, that he might show forth his power unto future generations.

And now behold, one purpose hath he fulfilled, even to the restoration of many thousands of the Lamanites to the knowledge of the truth; and he hath shown forth his power in them, and he will also still show forth his power in them unto future generations; therefore they shall be preserved.

Therefore I command you, my son Helaman, that ye be diligent in fulfilling all my words, and that ye be diligent in keeping the commandments of God as they are written.

And now, I will speak unto you concerning those twenty-four plates, that ye keep them, that the mysteries and the works of darkness, and their secret works, or the secret works of those people who have been destroyed, may be made manifest unto this people; yea, all their murders, and robbings, and their plunderings, and all their wickedness and abominations, may be made manifest unto this people; yea, and that ye preserve these interpreters.

For behold, the Lord saw that his people began to work in darkness, yea, work secret murders and abominations; therefore the Lord said, if they did not repent they should be destroyed from off the face of the earth.

- 23 Мөн Их Эзэн хэлсэн нь: Надад үйлчлэх өөрийн хүмүүстээ мэдүүлж болохын тулд, би тэдэнд ах дүүсийнх нь үйлүүдийг, тийм ээ, тэдний нууц үйлийг, мөн тэдний харанхуйн үйлүүдийг, мөн тэдний ёс бус жигшүүрт хэргүүдийг мэдүүлж болохын тулд би өөрийн зарц Газелемд, харанхуйг гэрлээр гийгүүлэх чулууг бэлтгэн өгөх болно.
- 24 Мөн эдүгээ, хүү минь, эдгээр хөрвүүлэгчид нь Бурханы ийн хэлсэн үг гүйцэлдэж болохын тул бэлтгэгдсэн юм, хэлрүүн:
- 25 Би тэдний бүх нууц үйл мөн жигшүүрт хэргүүдийг харанхуйгаас гэрэлд гарган авчрах болно; мөн тэд наманчлахгүй аваас би тэднийг газрын гадаргуугаас устгах болно; мөн хойшид уг нутгийг эзэмших үндэстэн бүрд, тэдний бүх нууц мөн жигшүүрт хэргүүдийг би гэрэлд гарган мэдүүлэх болно.
- 26 Мөн эдүгээ, хүү минь, тэд наманчлаагүйг бид харж байна; тиймийн тул тэд устгагдсан ажгуу, мөн одоог хүртэл Бурханы үг гүйцэлдсээр ирсэн билээ; тийм ээ, тэдний нууц жигшүүрт хэргүүд харанхуйгаас авчрагдаж мөн бидэнд мэдүүлэгдсэн бөлгөө.
- 27 Мөн эдүгээ, хүү минь, чи тэдний бүх тангараг, мөн тэдний гэрээ, мөн тэдний нууц жигшүүрт хэргүүд дэх хэлэлцээрүүдийг нууцал хэмээн би чамд зарлиглаж байна, тийм ээ, тэд тэдгээрийг мэдэхгүй байхын тулд, тэд харанхуйд унаж түүнчлэн мөн устгагдах вий хэмээхийн учир тэдний бүх дохио хийгээд гайхашралуудыг энэ хүмүүсээс чи нуух болно.
- 28 Учир нь болгоогтун, тэд үйлдээ бүрэн боловсрох үед харанхуйг үйлдэгч тэд бүгдийн дээр Бурханы хүчний дагуу устгал ирнэ гэсэн зүхэл энэ бүх нутгийн дээр буй; тиймийн тул энэ хүмүүс устгагдахгүй байгаасай хэмээн би хүсч байна.
- 29 Тиймийн тул чи тэдний эдгээр гэрээ хийгээд тангаргийнх нь нууц төлөвлөгөөнүүдийг энэ хүмүүсээс далдал, мөн зөвхөн тэдний ёс бус байдал хийгээд тэдний аллагууд мөн тэдний жигшүүрт хэргүүдийг л чи тэдэнд мэдүүлэх болно; мөн чи тэдэнд тийм ёс бус мөн жигшүүрт хэргүүд хийгээд аллагуудыг жигшин зэвүүцэхийг заах болно; мөн түүнчлэн эдгээр хүмүүс өөрсдийн ёс байдал бус мөн жигшүүрт хэргүүд мөн өөрсдийн аллагуудын улмаас устгагдсан хэмээн чи тэдэнд заах болно.

And the Lord said: I will prepare unto my servant Gazelem, a stone, which shall shine forth in darkness unto light, that I may discover unto my people who serve me, that I may discover unto them the works of their brethren, yea, their secret works, their works of darkness, and their wickedness and abominations.

And now, my son, these interpreters were prepared that the word of God might be fulfilled, which he spake, saying:

I will bring forth out of darkness unto light all their secret works and their abominations; and except they repent I will destroy them from off the face of the earth; and I will bring to light all their secrets and abominations, unto every nation that shall hereafter possess the land.

And now, my son, we see that they did not repent; therefore they have been destroyed, and thus far the word of God has been fulfilled; yea, their secret abominations have been brought out of darkness and made known unto us.

And now, my son, I command you that ye retain all their oaths, and their covenants, and their agreements in their secret abominations; yea, and all their signs and their wonders ye shall keep from this people, that they know them not, lest peradventure they should fall into darkness also and be destroyed.

For behold, there is a curse upon all this land, that destruction shall come upon all those workers of darkness, according to the power of God, when they are fully ripe; therefore I desire that this people might not be destroyed.

Therefore ye shall keep these secret plans of their oaths and their covenants from this people, and only their wickedness and their murders and their abominations shall ye make known unto them; and ye shall teach them to abhor such wickedness and abominations and murders; and ye shall also teach them that these people were destroyed on account of their wickedness and abominations and their murders.

- 30 Учир нь болгоогтун, тэд өөрсдийнх нь дунд тэдний алдсуудынх нь талаар тэдэнд тунхаглахаар ирсэн Их Эзэний бүх бошиглогчдыг хөнөөсөн юм; мөн тэдний хөнөөсөн тэдний цус өөрсдийнх нь алуурчдын дээр өс хонзон авчрахын тулд Их Эзэн Бурхандаа хандан хашгирсан болой; мөн тийн Бурханы шүүлт эдгээр харанхуйг мөн нууц хуйвалдааныг үйлдэгсдийн дээр ирсэн юм.
- 31 Тийм ээ, мөн тэд үйлдээ боловсорч гүйцэхээсээ өмнө наманчлахгүй аваас, тэдгээр харанхуйг хийгээд нууц хуйвалдааныг үйлдэгсдэд, бүр устгагдах болтол нь уг нутаг үеийн үед мөн үүрд зүхэгдэг.
- 32 Мөн эдүгээ, хүү минь, чамд миний ярьсан үгсийг санагтун; тэдгээр нууц төлөвлөгөөнүүдийг энэ хүмүүст бүү даатга, харин тэдэнд нүглийн хийгээд алдсын эсрэг үүрдийн үзэн ядалтыг сурга.
- 33 Наманчлал, мөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг тэдэнд номло; өөрсдийгөө даруусгаж мөн зүрх сэтгэлдээ даруу мөн номхон байхыг тэдэнд заа; чөтгөрийн уруу таталт болгоныг, Их Эзэн Есүс Христэд итгэх өөрсдийн итгэлээр сөрөн зогсохыг тэдэнд заа.
- 34 Сайн үйлүүдээс хэзээ ч үл залхаж, харин зүрх сэтгэлдээ даруу, номхон дөлгөөн байхыг тэдэнд заа; тиймүүд нь өөрсдийн бодгальд амар амгаланг олохын учир болой.
- 35 Ай, санагтун, хүү минь, мөн насны залууд мэргэн ухаанд суралц; тийм ээ, насны залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун.
- 36 Тийм ээ, мөн өөрт хэрэгтэй бүх дэмжлэгийн тулд Бурханаас гуй; тийм ээ, бүхий л үйлүүд тань Их Эзэний төлөө байг, мөн чи хаана ч явсан Их Эзэнтэй нэгдмэл юм; тийм ээ, бүх бодол санаа чинь Их Эзэнд чиглэсэн байг; тийм ээ, зүрх сэтгэлийн тань хайр Их Эзэн дээр үүрд байрлаг.
- 37 Бүх үйлүүдээ Их Эзэнтэй зөвлөгтүн, мөн тэрээр чамайг сайны төлөө чиглүүлэх болно; тийм ээ, чи үдэш унтахаар хэвтэхдээ, тэрээр нойронд чинь чамайг манаж болохын тулд Их Эзэний төлөө хэвт; мөн өглөө босохдоо зүрх сэтгэл чинь Бурханд хандах талархлаар дүүрэн байг; мөн хэрэв чи эдгээр зүйлийг хийх аваас эцсийн өдөр өргөгдөх болно.

For behold, they murdered all the prophets of the Lord who came among them to declare unto them concerning their iniquities; and the blood of those whom they murdered did cry unto the Lord their God for vengeance upon those who were their murderers; and thus the judgments of God did come upon these workers of darkness and secret combinations.

Yea, and cursed be the land forever and ever unto those workers of darkness and secret combinations, even unto destruction, except they repent before they are fully ripe.

And now, my son, remember the words which I have spoken unto you; trust not those secret plans unto this people, but teach them an everlasting hatred against sin and iniquity.

Preach unto them repentance, and faith on the Lord Jesus Christ; teach them to humble themselves and to be meek and lowly in heart; teach them to withstand every temptation of the devil, with their faith on the Lord Jesus Christ.

Teach them to never be weary of good works, but to be meek and lowly in heart; for such shall find rest to their souls.

O, remember, my son, and learn wisdom in thy youth; yea, learn in thy youth to keep the commandments of God.

Yea, and cry unto God for all thy support; yea, let all thy doings be unto the Lord, and whithersoever thou goest let it be in the Lord; yea, let all thy thoughts be directed unto the Lord; yea, let the affections of thy heart be placed upon the Lord forever.

Counsel with the Lord in all thy doings, and he will direct thee for good; yea, when thou liest down at night lie down unto the Lord, that he may watch over you in your sleep; and when thou risest in the morning let thy heart be full of thanks unto God; and if ye do these things, ye shall be lifted up at the last day.

38 Мөн эдүгээ, хүү минь, бидний эцэг өвгөдийн бөмбөрцөг эсвээс чиглүүлэгч гэж нэрлэсэн тэр зүйлийн талаар хэлэх зарим зүйл надад буй—өөрөөр хэлбэл бидний эцэг өвгөд үүнийг Лиахона, хөрвүүлбээс луужин гэж нэрлэсэн юм; мөн Их Эзэн үүнийг бэлтгэсэн бөлгөө.

39 Мөн болгоогтун, иймэрхүү маягийн нарийн урыг ямар ч хүн бүтээж чадахгүй. Мөн болгоогтун, энэ нь аглаг буйдад аялах тэдний замыг бидний эцэг өвгөдөд үзүүлэхийн тулд бэлтгэгдсэн ажгуу.

40 Мөн энэ нь тэдний төлөө Бурханд итгэх итгэлийнх нь дагуу ажилладаг байжээ; тиймийн тул, хэрэв тэд Бурхан тэр зүүнүүдээр тэдний явах ёстой замыг заалгаж чадна гэсэн итгэлтэй байвал, болгоогтун, энэ нь хийгддэг байжээ; тиймийн тул тэдэнд энэхүү гайхамшиг, мөн түүнчлэн бусад олон гайхамшиг Бурханы хүчээр өдөр өдрөөр авчрагдсан бөлгөө.

41 Гэсэн хэдий ч, тэдгээр гайхамшгууд өчүүхэн арга хэрэгслүүдээр гүйцэлдсэн учир энэ нь тэдэнд ер бусын ажлуудыг үзүүлсэн бөлгөө. Тэд хойрго байж, мөн итгэлээ бас хичээнгүй байдлаа бодитой болгохоо мартсан юм, мөн тэгээд тэдгээр ер бусын ажлууд зогссон билээ, мөн тэд аян замдаа урагшилсангүй;

42 Тиймийн тул, тэд өөрсдийн зөрчлүүдийн учир тэд аглаг буйдад саатаж, өөрөөр хэлбэл чиг замаа шууд хөөсөнгүй, мөн өлссөнөөс бас цангаснаас зовоогдож байв.

43 Мөн эдүгээ, хүү минь, би чамайг эдгээр зүйл далд утгагүй бус хэмээн ойлгоосой хэмээнэ; учир нь бидний эцэг өвгөд энэ луужинд анхаарлаа хандуулахдаа хойрго байснаас, (эдүгээ эдгээр зүйл нь зуурдынх байв) тэд дэгжээгүй юм; бүр тэрчлэн сүнслэг зүйлүүдийн хувьд ч тийм болой.

44 Учир нь болгоогтун, мөнхийн жаргалд хүрэх шулуун замыг та нарт заах Христийн үгэнд анхаарлаа хандуулах нь амлагдсан нутагт хүрэх шулуун замыг тэдэнд заах уг луужинд эцэг өвгөд маань анхаарлаа хандуулахад байсны адил амархан болой.

And now, my son, I have somewhat to say concerning the thing which our fathers call a ball, or director—or our fathers called it Liahona, which is, being interpreted, a compass; and the Lord prepared it.

And behold, there cannot any man work after the manner of so curious a workmanship. And behold, it was prepared to show unto our fathers the course which they should travel in the wilderness.

And it did work for them according to their faith in God; therefore, if they had faith to believe that God could cause that those spindles should point the way they should go, behold, it was done; therefore they had this miracle, and also many other miracles wrought by the power of God, day by day.

Nevertheless, because those miracles were worked by small means it did show unto them marvelous works. They were slothful, and forgot to exercise their faith and diligence and then those marvelous works ceased, and they did not progress in their journey;

Therefore, they tarried in the wilderness, or did not travel a direct course, and were afflicted with hunger and thirst, because of their transgressions.

And now, my son, I would that ye should understand that these things are not without a shadow; for as our fathers were slothful to give heed to this compass (now these things were temporal) they did not prosper; even so it is with things which are spiritual.

For behold, it is as easy to give heed to the word of Christ, which will point to you a straight course to eternal bliss, as it was for our fathers to give heed to this compass, which would point unto them a straight course to the promised land.

45 Мөн эдүгээ би хэлнэ, энэ зүйлд хэв шинж үгүй гэж үү? Учир нь үүний чигийг дагаснаар, бидний эцэг өвгөдийг амлагдсан нутагт энэ чиглүүлэгч авчирсан нь гарцаагүйн адил, хэрэв бид тэдгээрийн чигийг нь дагавал Христийн үгс биднийг энэ харамслын хөндийн цаад талын илүү дээр амлалтын нутагт аваачих болно.

46 Ай хүү минь, уг замын амархны учир хойргошихгүй байцгаая; учир нь бидний эцэг өвгөдөд ийм байлаа; учир нь, хэрэв тэд харсан бол тэд амьдарч болохуйцаар тэдэнд бэлтгэгдсэн байв; бүр энэ нь бидний хувьд ч ийм билээ. Зам нь бэлтгэгдсэн, мөн хэрэв бид харвал бид үүрд амьдарч болох болно.

47 Мөн эдүгээ, хүү минь, чи эдгээр ариун нандин зүйлүүдэд санаа тавихыг мэд, тийм ээ, чи Бурханд найдан амьдрахаа мэдтүгэй. Энэ хүмүүст оч мөн үгийг тунхагла, мөн чанд бай. Хүү минь, сайныг ерөөе.

And now I say, is there not a type in this thing? For just as surely as this director did bring our fathers, by following its course, to the promised land, shall the words of Christ, if we follow their course, carry us beyond this vale of sorrow into a far better land of promise.

O my son, do not let us be slothful because of the easiness of the way; for so was it with our fathers; for so was it prepared for them, that if they would look they might live; even so it is with us. The way is prepared, and if we will look we may live forever.

And now, my son, see that ye take care of these sacred things, yea, see that ye look to God and live. Go unto this people and declare the word, and be sober. My son, farewell.

## Алма 38

- 1 Хүү минь, миний үгсэд чих тавь, учир нь би чамд хэлнэ, бүр Хиламанд хэлсний адил, та нар Бурханы зарлигуудыг дагахын хэрээр та нар уг нутагт дэгжих болно; мөн та нар Бурханы зарлигуудыг дагахгүй байхынхаа хэрээр та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно.
- 2 Мөн эдүгээ, хүү минь, чиний гуйвшгүй байдал мөн Бурханд итгэх итгэлийн чинь төлөө би чиний учир маш ихээр баясна гэдэгтээ найдаж байна; учир нь чи залуудаа Их Эзэн Бурхандаа хандаж эхэлсэн шигээ, тэрчлэн би чамайг түүний зарлигийг дагахаа үргэлжлүүлнэ хэмээн найддаг; учир нь эцсээ хүртэл тэвчих тэр нь адислагдах болно.
- 3 Би чамд хэлнэ, хүү минь, би аль хэдийн чамд маш ихээр баярласан, учир нь зорамчуудын хүмүүсийн дундах чиний итгэлтэй байдал мөн чиний хичээнгүй чанар, мөн чиний тэвчээр мөн чиний удаан хугацааны тэсвэрийн учир буюу.
- 4 Учир нь чамайг хүлүүлсэн байсныг би мэднэ; тийм ээ, мөн түүнчлэн чи үгийн төлөө чулуугаар шидүүлснийг би мэднэ; мөн Их Эзэн чамтай хамт байсан учир чи энэ бүгдийг тэвчээртэйгээр хүлцсэн; мөн эдүгээ Их Эзэн чамайг чөлөөлснийг чи мэднэ.
- 5 Мөн эдүгээ Шиблон, хүү минь, чи Бурханд найдлага тавихын хэрээр өөрийн бэрхшээл, мөн зүдгүүр, мөн зовлонгуудаасаа ангижруулагдаж мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг чамайг санаасай хэмээнэ би.
- 6 Эдүгээ, хүү минь, эдгээр зүйлийг би өөрийнхөөрөө мэддэг хэмээн би чамайг бүү бодоосой гэнэ, харин эдгээр зүйлийг надад мэдүүлдэг нь надад орших Бурханы Сүнс юм; учир нь хэрэв би Бурханаар төрөөгүйсэн бол би эдгээр зүйлийг мэдэхгүй байх байсан.

## Alma 38

My son, give ear to my words, for I say unto you, even as I said unto Helaman, that inasmuch as ye shall keep the commandments of God ye shall prosper in the land; and inasmuch as ye will not keep the commandments of God ye shall be cut off from his presence.

And now, my son, I trust that I shall have great joy in you, because of your steadiness and your faithfulness unto God; for as you have commenced in your youth to look to the Lord your God, even so I hope that you will continue in keeping his commandments; for blessed is he that endureth to the end.

I say unto you, my son, that I have had great joy in thee already, because of thy faithfulness and thy diligence, and thy patience and thy long-suffering among the people of the Zoramites.

For I know that thou wast in bonds; yea, and I also know that thou wast stoned for the word's sake; and thou didst bear all these things with patience because the Lord was with thee; and now thou knowest that the Lord did deliver thee.

And now my son, Shiblon, I would that ye should remember, that as much as ye shall put your trust in God even so much ye shall be delivered out of your trials, and your troubles, and your afflictions, and ye shall be lifted up at the last day.

Now, my son, I would not that ye should think that I know these things of myself, but it is the Spirit of God which is in me which maketh these things known unto me; for if I had not been born of God I should not have known these things.



- 7 Гэвч болгоогтун, Их Эзэн өөрийн агуу нигүүлсэлдээ өөрийн хүмүүсийн дундах устгалын ажлыг би зогсоох ёстой хэмээн надад тунхаглуулахаар тэнгэр элчээ илгээсэн юм; тийм ээ, мөн би тэнгэр элчийг нүүр тулан харж, мөн тэрээр надтай ярьсан, мөн түүний дуу хоолой аянга мэт байж, мөн энэ нь бүх газрыг доргиосон бөлгөө.
- 8 Мөнхүү улиран тохиох дор би гурван өдөр мөн гурван шөнө бодгалийн хамгийн зовиуртай өвдөлт хийгээд шаналалд байв; мөн хэзээ ч, би Их Эзэн Есүс Христэд нигүүлслийн тул залбиран гуйх хүртлээ, би нүглүүдийнхээ ангижралыг хүлээн аваагүй билээ. Гэвч болгоогтун, би түүнээс залбиран гуйж тэгээд өөрийн бодгальд амгаланг олсон билээ.
- 9 Мөн эдүгээ, хүү минь, чи мэргэн ухаанд суралцаж болно хэмээн, чи зөвхөн Христэд мөн түүгээр бус аваас хүмүүн аврагдаж чадах өөр зам эсвээс арга үгүй гэдгийг надаас суралцаж болохын тул би үүнийг чамд хэлэв. Болгоогтун, тэр бол дэлхийн амь мөн гэрэл билээ. Болгоогтун, тэр бол үнэн хийгээд зөв шударгын үг билээ.
- 10 Мөн эдүгээ, чи үгийг зааж эхэлсэн шигээ, тэрчлэн би чамайг үргэлжлүүлэн заагаасай хэмээнэ; мөн чамайг бүх зүйлд хичээнгүй мөн өөрийгөө захирах чадвартай байгаасай хэмээнэ би.
- 11 Бардамналд хөөрөхгүйгээ мэд; тийм ээ, өөрийн мэргэн ухаанд, бас өөрийн их хүчээр сагсуурахгүй байхаа мэд.
- 12 Зоригийг хэрэглэ, гэвч бүү дээрэлх; мөн түүнчлэн чи хайраар дүүргэгдэж болохын тулд бүх хүслээ хазаарлахыг мэдээрэй; чи залхаг байдлаас татгалзахыг мэдээрэй.
- 13 Зорамчуудын адил бүү залбир, учир нь тэд хүмүүнд сонсохоор мөн өөрсдийн мэргэн ухааныг магтуулахаар залбирдгийг чи харсан болой.
- 14 Ай Бурхан, бид ах дүүсээсээ илүү учир танд би талархъя гэж бүү хэл; харин: Ай Их Эзэн, миний зохисгүйг өршөө, мөн ах дүүсийг минь нигүүлслээрээ санаач хэмээн хэл—тийм ээ, Бурханы өмнө зохисгүй байдлаа цаг үргэлж хүлээж бай.

But behold, the Lord in his great mercy sent his angel to declare unto me that I must stop the work of destruction among his people; yea, and I have seen an angel face to face, and he spake with me, and his voice was as thunder, and it shook the whole earth.

And it came to pass that I was three days and three nights in the most bitter pain and anguish of soul; and never, until I did cry out unto the Lord Jesus Christ for mercy, did I receive a remission of my sins. But behold, I did cry unto him and I did find peace to my soul.

And now, my son, I have told you this that ye may learn wisdom, that ye may learn of me that there is no other way or means whereby man can be saved, only in and through Christ. Behold, he is the life and the light of the world. Behold, he is the word of truth and righteousness.

And now, as ye have begun to teach the word even so I would that ye should continue to teach; and I would that ye would be diligent and temperate in all things.

See that ye are not lifted up unto pride; yea, see that ye do not boast in your own wisdom, nor of your much strength.

Use boldness, but not overbearance; and also see that ye bridle all your passions, that ye may be filled with love; see that ye refrain from idleness.

Do not pray as the Zoramites do, for ye have seen that they pray to be heard of men, and to be praised for their wisdom.

Do not say: O God, I thank thee that we are better than our brethren; but rather say: O Lord, forgive my unworthiness, and remember my brethren in mercy—yea, acknowledge your unworthiness before God at all times.

15 Мөн Их Эзэн бодгалийг чинь адисалж мөн амгалан суулгахаар чамайг өөрийн хаант улсад эцсийн өдөр хүлээн авах болтугай. Эдүгээ явагтун, хүү минь, мөн үгийг энэ хүмүүст заагтун. Чанд байгтун. Хүү минь, сайныг ерөөе.

And may the Lord bless your soul, and receive you at the last day into his kingdom, to sit down in peace.  
Now go, my son, and teach the word unto this people.  
Be sober. My son, farewell.

*Хүү Кориантондоо өгсөн Алмагийн зарлигууд орш-  
вой.*

## Алма 39

- 1 Мөн эдүгээ, хүү минь, ахад чинь хэлснээс өөр хэлэх зарим нэгэн зүйл надад байна; учир нь болгоогтун, Бурханы зарлигуудыг дагах ахынхаа тууштай байдал, түүний итгэл дүүрэн байдал, мөн түүний хичээнгүй чанарыг чи анхаараагүй гэж үү? Болгоогтун, тэр чамд сайн үлгэр жишээ үзүүлээгүй гэж үү
- 2 Учир нь чи ахынхтайгаа адил тийм их анхаарлыг, Зорамын хүмүүсийн дунд миний үгсэд хандуулаагүй. Эдүгээ энэ бол чамайг шүүмжлэх миний зүйл; чи өөрийн хүч мөн өөрийн мэргэн ухаанд сагсуурч байсан болой.
- 3 Мөн энэ нь бүгд бус, хүү минь. Чи надад харамсалтай болох түүнийг хийсэн; учир нь чи тохинууллыг орхиж, мөн леменчүүдийн хилийн ойролцоох Широны нутаг тийш янхан эм Изабелын араас одсон шүү дээ.
- 4 Тийм ээ, тэр эмэгтэй олон эрийн зүрх сэтгэлийг хулгайлсан, гэвч энэ нь шалтаг биш юм, хүү минь. Чи өөрт даатгагдан хүлээлгэсэн тэр тохинууллыг анхаарах ёстой байсан.
- 5 Хүү минь, Их Эзэний мэлмийд эдгээр зүйл жигшүүрт хэрэг гэдгийг; тийм ээ, гэмгүй цусыг урсгах эсвээс Ариун Сүнснийг үгүйсгэхээс бусад бүх нүглүүдээс хамгийн жигшүүрт зүйл болохыг чи мэдэхгүй гэж үү
- 6 Учир нь болгоогтун, хэрэв чамд нэгэнтээ оршиж байсан, мөн чи үүнийг мэдэх атал Ариун Сүнснийг чи үгүйсгэх аваас, болгоогтун, энэ бол уучлагдашгүй нүгэл мөн; тийм ээ, мөн Бурханы гэрэл болон мэдлэгийн эсрэг аллага хийдэг хэн боловч, өршөөлийг хүртэх нь амар бус байна; тийм ээ, хүү минь, өршөөлийг хүртэх нь түүнд амар бус байна гэдгийг би чамд хэлнэ.
- 7 Мөн эдүгээ, хүү минь, ийм агуу гэмт үйлд чамайг буруугүй байсан болоосой хэмээн би Бурханд хандана. Хэрэв энэ нь чиний тусын тулд байгаагүйсэн бол, би гэмт үйлүүдийг чинь нуршин, сэтгэлийг чинь шалгалгахгүй сэн.

*The commandments of Alma to his son Corianton.*

## Alma 39

And now, my son, I have somewhat more to say unto thee than what I said unto thy brother; for behold, have ye not observed the steadiness of thy brother, his faithfulness, and his diligence in keeping the commandments of God? Behold, has he not set a good example for thee?

For thou didst not give so much heed unto my words as did thy brother, among the people of the Zoramites. Now this is what I have against thee; thou didst go on unto boasting in thy strength and thy wisdom.

And this is not all, my son. Thou didst do that which was grievous unto me; for thou didst forsake the ministry, and did go over into the land of Siron among the borders of the Lamanites, after the harlot Isabel.

Yea, she did steal away the hearts of many; but this was no excuse for thee, my son. Thou shouldst have tended to the ministry wherewith thou wast entrusted.

Know ye not, my son, that these things are an abomination in the sight of the Lord; yea, most abominable above all sins save it be the shedding of innocent blood or denying the Holy Ghost?

For behold, if ye deny the Holy Ghost when it once has had place in you, and ye know that ye deny it, behold, this is a sin which is unpardonable; yea, and whosoever murdereth against the light and knowledge of God, it is not easy for him to obtain forgiveness; yea, I say unto you, my son, that it is not easy for him to obtain a forgiveness.

And now, my son, I would to God that ye had not been guilty of so great a crime. I would not dwell upon your crimes, to harrow up your soul, if it were not for your good.

- 8 Гэвч болгоогтун, чи өөрийн гэмт үйлүүдийг Бурханаас нууж чадахгүй; мөн чи наманчлахгүй аваас тэдгээр нь эцсийн өдөр чиний эсрэг гэрчлэл болон босох болно.
- 9 Эдүгээ хүү минь, би чамайг наманчлаасай мөн нүглүүдээ орхиосой, мөн нүдээрээ шунасныхаа араас дахин бүү яваасай, харин эдгээр бүх зүйлийг өөртөө хориглоосой хэмээнэ; учир нь чи үүнийг хийхгүйгээр Бурханы хаант улсыг өвлөх аргагүй. Ай санагтун, үүнийг өөр дээрээ авч, мөн эдгээр зүйлд өөртөө хориг тавь.
- 10 Мөн би зорьсон үйлүүдийнхээ талаар ах нартайгаа зөвлөхийг өөртөө хүлээхийг чамд зарлиг болгож байна; учир нь болгоогтун, чи залуугаараа байна, мөн чамд ах нараараа залуулж заалгаж байх хэрэгцээ бий. Мөн тэдний зөвлөгөөг анхаарагтун.
- 11 Өөрийгөө ямар нэг хоосон эсвэл мунхаг зүйлд удирдуулахыг бүү тэвч; чөтгөр зүрх сэтгэлийг чинь тэдгээр ёс бус янхан эмсийн хойноос дахин зайцуулан удирдахыг бүү тэвч. Болгоогтун, ай хүү минь, зорамчуудын дээр чи ямар их алдсыг авчирсан билээ; учир нь тэд чиний биеэ авч явахыг хараад миний үгсэд итгэхгүй байсан буйза.
- 12 Мөн эдүгээ Их Эзэний Сүнс надад хэлж байна: Хүүхдүүддээ сайныг хийхийг зарлигла, эс тэгвээс тэд олон хүмүүний зүрх сэтгэлийг устгал уруу удирдахвий; тиймийн тул, хүү минь, Бурханаас эмээх айдаст, чи алдсуудаасаа түдгэлзэх ёстойг би чамд зарлиглана;
- 13 Чи өөрийн бүх оюун, хүч мөн чадлаараа Их Эзэнд хандахыг; чи өөр хэний ч зүрх сэтгэлийг дахин ёс бусыг үйлдэхэд дагуулахгүй байхыг; харин үүний оронд тэдэнд эргэн очиж, мөн өөрийн алдаанууд хийгээд өөрийн үйлдсэн бурууг хүлээхийг буюу.
- 14 Баялгийг болон энэ дэлхийн хоосон зүйлсийг бүү эрэлхийл; учир нь болгоогтун, чи тэдгээрийг өөртөйгээ аваад явж чадахгүй.
- 15 Мөн эдүгээ, хүү минь, би чамд Христийн ирэлтийн талаар зарим нэгийг хэлэхийг хүснэ. Болгоогтун, би чамд хэлнэ, дэлхийн нүглүүдийг зайлуулан авахаар гарцаагүй ирэх нь тэр юм; тийм ээ, тэр өөрийн хүмүүст авралын баярт мэдээг тунхаглахаар ирэх бөлгөө.

But behold, ye cannot hide your crimes from God; and except ye repent they will stand as a testimony against you at the last day.

Now my son, I would that ye should repent and forsake your sins, and go no more after the lusts of your eyes, but cross yourself in all these things; for except ye do this ye can in nowise inherit the kingdom of God. Oh, remember, and take it upon you, and cross yourself in these things.

And I command you to take it upon you to counsel with your elder brothers in your undertakings; for behold, thou art in thy youth, and ye stand in need to be nourished by your brothers. And give heed to their counsel.

Suffer not yourself to be led away by any vain or foolish thing; suffer not the devil to lead away your heart again after those wicked harlots. Behold, O my son, how great iniquity ye brought upon the Zoramites; for when they saw your conduct they would not believe in my words.

And now the Spirit of the Lord doth say unto me: Command thy children to do good, lest they lead away the hearts of many people to destruction; therefore I command you, my son, in the fear of God, that ye refrain from your iniquities;

That ye turn to the Lord with all your mind, might, and strength; that ye lead away the hearts of no more to do wickedly; but rather return unto them, and acknowledge your faults and that wrong which ye have done.

Seek not after riches nor the vain things of this world; for behold, you cannot carry them with you.

And now, my son, I would say somewhat unto you concerning the coming of Christ. Behold, I say unto you, that it is he that surely shall come to take away the sins of the world; yea, he cometh to declare glad tidings of salvation unto his people.

- 16 Мөн эдүгээ, хүү минь, эдгээр баярт мэдээг энэ хүмүүст тунхаглахаар, тэдний оюуныг бэлтгэхээр чиний дуудагдсан тохинуулал энэ байв; өөрөөр хэлбэл тэдний дээр аврал ирж болохын тулд, тэд хүүхдүүдийнхээ оюуныг түүний ирэлтийн үед үгийг сонсгоход бэлтгэж болохын тулд буюу.
- 17 Мөн эдүгээ би үүний тухайд чиний санааг амраая. Болгоогтун, чи эдгээр зүйл яагаад ийм эртнээс мэдэгдэх ёстойд гайхаж буй. Болгоогтун, би чамд хэлнэ, Бурханд энэ үеийн бодгаль түүний ирэлтийн үед байх бодгалийн адил эрхэм бус уу
- 18 Гэтэлгэлийн төлөвлөгөө энэ хүмүүст мэдүүлэгдэх нь тэдний хүүхдүүдэд мэдүүлэгдсэн байхтай нэгэн адил зайлшгүй бус уу
- 19 Энэ цагт Их Эзэн эдгээр баярт мэдээг тунхаглуулахаар тэнгэр элчээ хүүхдүүдэд минь илгээхийн адил, өөрөөр хэлбэл түүний ирэлтийн дараах үеийн адил бидэнд ч илгээх нь амархан бус гэж үү

And now, my son, this was the ministry unto which ye were called, to declare these glad tidings unto this people, to prepare their minds; or rather that salvation might come unto them, that they may prepare the minds of their children to hear the word at the time of his coming.

And now I will ease your mind somewhat on this subject. Behold, you marvel why these things should be known so long beforehand. Behold, I say unto you, is not a soul at this time as precious unto God as a soul will be at the time of his coming?

Is it not as necessary that the plan of redemption should be made known unto this people as well as unto their children?

Is it not as easy at this time for the Lord to send his angel to declare these glad tidings unto us as unto our children, or as after the time of his coming?

## Алма 40

- 1 Эдүгээ хүү минь, чамд миний нэмж хэлэх зүйл энэ байна; учир нь оюун чинь нас барагсдын амилуулалтын талаар зовниж буйг би ухаарч байна.
- 2 Болгоогтун, би чамд хэлнэ, ямар ч амилуулалт—эсвээс, өөрөөр хэлбэл, энэ зуурдын байдал үхэшгүй байдалд, энэ ялзрал ялзаршгүй байдалд тавигдах нь—Христийн ирэлтийн дарааг хүртэл байхгүйг би хэлэх сэн.
- 3 Болгоогтун, тэрээр нас барагсдын амилуулалтыг улируулан авчирдаг. Гэвч болгоогтун, хүү минь, амилуулалт одоохондоо болоогүй. Эдүгээ, би чамд нэг нууцыг задалъя; гэсэн хэдий ч Бурханаас өөрөөс нь бусад хэн ч үл мэдэх хадгалагдсан олон нууц байдаг. Гэвч би мэдэж болохын тулд Бурханаас хичээнгүйлэн лавласан нэг зүйлийг чамд үзүүлье—амилуулалтын талаар буюу.
- 4 Болгоогтун, бүгд нас барагсдаас ирэх цаг товлогдсон буй. Эдүгээ энэ цаг хэзээ ирэхийг хэн ч мэдэхгүй; харин Бурхан товлогдсон тэр цагийг мэддэг.
- 5 Эдүгээ, хүмүүн нь нас барагсдаас ирэх нэг дэх удаад, эсвэл хоёр дахь удаад, эсвэл гурав дахь удаад байх эсэх нь үл хамаарах болно; учир нь Бурхан эдгээр бүх зүйлийг мэддэг; мөн энэ нь тохиохыг—үхэгсдээс бүгд босох цаг товлогдсоныг мэдсэн нь надад хангалттай.
- 6 Эдүгээ үхэх цаг мөн амилуулалтын цагийн хооронд хэсэг хугацаа байх нь зайлшгүй.
- 7 Мөн эдүгээ энэ үхэх цагаас амилуулалтын тогтоогдсон цагийг хүртэл хүмүүний сүнс яахыг би лавлах уу
- 8 Эдүгээ хүмүүн босох нэгээс олон ээлж товлогдсон эсэх нь хамаагүй; учир нь бүгд нэг дор үхэхгүй, мөн энэ нь хамаагүй; бүгд Бурханы хувьд нэг өдөр мэт байж, мөн тэрхүү цаг нь зөвхөн хүмүүний хувьд хэмжигдсэн байдаг.

## Alma 40

Now my son, here is somewhat more I would say unto thee; for I perceive that thy mind is worried concerning the resurrection of the dead.

Behold, I say unto you, that there is no resurrection—or, I would say, in other words, that this mortal does not put on immortality, this corruption does not put on incorruption—until after the coming of Christ.

Behold, he bringeth to pass the resurrection of the dead. But behold, my son, the resurrection is not yet. Now, I unfold unto you a mystery; nevertheless, there are many mysteries which are kept, that no one knoweth them save God himself. But I show unto you one thing which I have inquired diligently of God that I might know—that is concerning the resurrection.

Behold, there is a time appointed that all shall come forth from the dead. Now when this time cometh no one knows; but God knoweth the time which is appointed.

Now, whether there shall be one time, or a second time, or a third time, that men shall come forth from the dead, it mattereth not; for God knoweth all these things; and it sufficeth me to know that this is the case—that there is a time appointed that all shall rise from the dead.

Now there must needs be a space betwixt the time of death and the time of the resurrection.

And now I would inquire what becometh of the souls of men from this time of death to the time appointed for the resurrection?

Now whether there is more than one time appointed for men to rise it mattereth not; for all do not die at once, and this mattereth not; all is as one day with God, and time only is measured unto men.

- 9 Тиймийн тул, нас барагсдаас босох тэр цаг нь хүмүүнд товлогдсон ажгуу; мөн үхлийн хийгээд амилуулалтын цагийн хооронд хугацаа буй. Мөн эдүгээ, энэ хугацааны талаар, хүмүүний сүнсэнд юу тохиолдох вэ гэдэг нь миний мэдэж авахаар Их Эзэнээс хичээнгүйлэн лавласан тэр зүйл билээ; мөн энэ нь миний мэддэг тэр зүйл бөлгөө.
- 10 Мөн бүгд босох тэр цаг ирэхэд, хүмүүнд товлосон бүх цагуудыг Бурхан мэддэгийг тэд мэдэх болно.
- 11 Эдүгээ, үхэл хийгээд амилуулалтын хоорондох сүнсний байдлын талаар—Болгоогтун, бүх хүмүүний сүнс энэ зуурдын биеийг орхимогцоо, тийм ээ, бүх хүмүүний сүнс, сайн эсвэл муу байлаа ч өөрсдөд нь амьдралыг өгсөн Бурханд, гэртээ аваачигддаг нь надад нэгэн тэнгэр элчээр мэдүүлэгдсэн билээ.
- 12 Мөнхүү тэгээд улиран тохиох дор, зөв шударга тэдний сүнс тэд өөрсдийн бүх бэрхшээлүүд мөн санаа зоволт хийгээд харамслаасаа амрах диваажин гэж нэрлэгдсэн аз жаргалын байдал, амар амгалангийн байдал, энхийн байдалд хүлээн авагдах болно.
- 13 Мөн тэгээд улиран тохиох дор, ёс бусыг үйлдэгчдийн, тийм ээ, хилэнцэт тэдний сүнснүүдэд—учир нь болгоогтун, Их Эзэний Сүнсний ямар ч хэсэг эсвээс хувь тэдэнд үгүй билээ; учир нь болгоогтун, тэд сайнаас илүүтэйгээр хилэнцэт үйлийг сонгосон бөлгөө; тиймийн тул чөтгөрийн сүнс тэдэнд орж, мөн тэдний гэрийг эзэмшилдээ авсан юм—мөн эдгээр нь гадаад харанхуйд хаягдах болно; уйлаан, мөн гаслан, мөн шүдээ хавирах нь байх болно, мөн энэ нь чөтгөрийн тааллаар боолчлогдсон учир өөрсдийнх нь алдсаас болой.
- 14 Эдүгээ энэ бол ёс бусыг үйлдэгчдийн сүнсний байдал болой, тийм ээ, харанхуйд, мөн тэдний дээр ирэх Бурханы уур болох галт хилэнг айн харуулдахын аймшигт байдалд буюу; тийн тэд энэ байдалд, түүнчлэн зөв шударгыг үйлдэгчид диваажинд, өөрсдийн амилуулалтын цагийг хүртэл үлдэнэ.

Therefore, there is a time appointed unto men that they shall rise from the dead; and there is a space between the time of death and the resurrection. And now, concerning this space of time, what becometh of the souls of men is the thing which I have inquired diligently of the Lord to know; and this is the thing of which I do know.

And when the time cometh when all shall rise, then shall they know that God knoweth all the times which are appointed unto man.

Now, concerning the state of the soul between death and the resurrection—Behold, it has been made known unto me by an angel, that the spirits of all men, as soon as they are departed from this mortal body, yea, the spirits of all men, whether they be good or evil, are taken home to that God who gave them life.

And then shall it come to pass, that the spirits of those who are righteous are received into a state of happiness, which is called paradise, a state of rest, a state of peace, where they shall rest from all their troubles and from all care, and sorrow.

And then shall it come to pass, that the spirits of the wicked, yea, who are evil—for behold, they have no part nor portion of the Spirit of the Lord; for behold, they chose evil works rather than good; therefore the spirit of the devil did enter into them, and take possession of their house—and these shall be cast out into outer darkness; there shall be weeping, and wailing, and gnashing of teeth, and this because of their own iniquity, being led captive by the will of the devil.

Now this is the state of the souls of the wicked, yea, in darkness, and a state of awful, fearful looking for the fiery indignation of the wrath of God upon them; thus they remain in this state, as well as the righteous in paradise, until the time of their resurrection.

- 15 Эдүгээ, амилуулалтын өмнөх энэ аз жаргалын байдал мөн сүнсний зовлонгийн байдлыг эхний нэгэн амилуулалт хэмээн ойлгосон зарим нь бий. Тийм ээ, би энэ нь нэгэн амилуулалт хэмээн нэрлэгдэж болохыг хүлээн зөвшөөрнө, сүнс эсвээс бодгалийн босгогдох нь мөн тэдний аз жаргалд эсвэл зовлонд хуваарилагдах нь, яригдсан үгсийн дагуу болой.
- 16 Мөн болгоогтун, эхний амилуулалт гэж буй хэмээн түүнчлэн яригдсан, Христийн үхлээс амилах хүртэл байсан мөн байгаа, эсвээс байх гэд бүгдийн амилуулалт буюу.
- 17 Эдүгээ, ийм маягаар яригдсан эхний амилуулалт нь сүнснүүдийн амилуулалт мөн тэднийг аз жаргал эсвэл зовлонд нь хуваарилагдах явдал хэмээн бид боддоггүй. Энэ нь ийм утгатай хэмээн чи бодож болохгүй.
- 18 Болгоогтун, би чамд хэлнэ, Үгүй; харин энэ нь Адамын өдрүүдээс Христийн амилалтыг хүртэлх тэдний сүнс биетэйгээ буцаж нэгдэх гэсэн утгатай юм.
- 19 Эдүгээ, зөв шударгыг үйлдэгчдийн нэгэн адил ёс бусыг үйлдэгчдийнх ч гэсэн яригдсан тэдний сүнс нь биетэйгээ нэгэн зэрэг нэгтгэгдэх эсэхийг би хэлэхгүй; тэд бүгд гарч ирнэ гэж миний хэлэх нь хангалттай байг; эсвээс өөрөөр хэлбэл, тэдний амилуулалт Христийн амилуулалтын дараа үхэх тэдний амилуулалтаас өмнө улиран тохиох болно.
- 20 Эдүгээ, хүү минь, тэдний амилуулалт Христийн амилалтын үед тохионо гэж би хэлээгүй; гэвч болгоогтун, би үүнийг өөрийн санаа болгон хэлье, зөв шударгыг үйлдэгчдийн сүнс мөн биес нь Христийн амилалтын үед, мөн түүнийг тэнгэрт дээшлэхэд дахин нэгтгэгдэх болно.
- 21 Харин энэ нь түүний амилалтын үед эсвэл дараа нь болох эсэхийг би хэлэхгүй; харин өдий хэрийг би хэлнэ, үхэл хийгээд биесийн амилуулалтын хооронд хугацаа буй, мөн нас барагсад босч ирнэ, мөн сүнс болон бие аль аль нь дахин нэгтгэгдэх болно, мөн Бурханы өмнө зогсохоор авчрагдан, мөн хийснийхээ дагуу шүүгдэх Бурханаас товлогдсон тэр цагийг хүртэл сүнсний байдал аз жаргалд эсвэл зовлонд байна.

Now, there are some that have understood that this state of happiness and this state of misery of the soul, before the resurrection, was a first resurrection. Yea, I admit it may be termed a resurrection, the raising of the spirit or the soul and their consignment to happiness or misery, according to the words which have been spoken.

And behold, again it hath been spoken, that there is a first resurrection, a resurrection of all those who have been, or who are, or who shall be, down to the resurrection of Christ from the dead.

Now, we do not suppose that this first resurrection, which is spoken of in this manner, can be the resurrection of the souls and their consignment to happiness or misery. Ye cannot suppose that this is what it meaneth.

Behold, I say unto you, Nay; but it meaneth the reuniting of the soul with the body, of those from the days of Adam down to the resurrection of Christ.

Now, whether the souls and the bodies of those of whom has been spoken shall all be reunited at once, the wicked as well as the righteous, I do not say; let it suffice, that I say that they all come forth; or in other words, their resurrection cometh to pass before the resurrection of those who die after the resurrection of Christ.

Now, my son, I do not say that their resurrection cometh at the resurrection of Christ; but behold, I give it as my opinion, that the souls and the bodies are reunited, of the righteous, at the resurrection of Christ, and his ascension into heaven.

But whether it be at his resurrection or after, I do not say; but this much I say, that there is a space between death and the resurrection of the body, and a state of the soul in happiness or in misery until the time which is appointed of God that the dead shall come forth, and be reunited, both soul and body, and be brought to stand before God, and be judged according to their works.



- 22 Тийм ээ, энэ нь бошиглогчдын амаар яригдсан тэдгээр зүйлүүдийн сэргээлтийг тохиолдуулах болно.
- 23 Сүнс нь биедээ, мөн бие нь сүнсэндээ сэргээгдэх болно; тийм ээ, мөн үе болон мөч болгон биедээ сэргээгдэх болно; тийм ээ, бүр толгойноос нэг ч үс гээгдэхгүй; харин бүх зүйл өөрсдийн зохих мөн төгс хэлбэртээ сэргээгдэх болно.
- 24 Мөн эдүгээ, хүү минь, энэ бол бошиглогчдын амаар яригдсан тэрхүү сэргээлт юм—
- 25 Мөн тэгээд зөв шударгыг үйлдэгсэд Бурханы хаант улсад туяарах болно.
- 26 Гэвч болгоогтун, аймшигт үхэл ёс бусыг үйлдэгсдийн дээр ирнэ; учир нь тэд зөв шударгад хамаарах зүйлүүдийн хувьд үхмэл юм; учир нь тэд цэвэр бус, мөн ямар ч цэвэр бус зүйл Бурханы хаант улсыг өвлөж авч чадахгүй; харин тэд зайлуулагдаж, мөн хилэнцэт асан өөрсдийн үйлүүдийн эсвээс өөрсдийн хийсэн ажлуудын үр жимсийг хүртэхээр хуваарилагдах болно; мөн тэд нэгэн гашуун аяганы шаарыг нь ч шавхан ууна.

Yea, this bringeth about the restoration of those things of which has been spoken by the mouths of the prophets.

The soul shall be restored to the body, and the body to the soul; yea, and every limb and joint shall be restored to its body; yea, even a hair of the head shall not be lost; but all things shall be restored to their proper and perfect frame.

And now, my son, this is the restoration of which has been spoken by the mouths of the prophets—

And then shall the righteous shine forth in the kingdom of God.

But behold, an awful death cometh upon the wicked; for they die as to things pertaining to things of righteousness; for they are unclean, and no unclean thing can inherit the kingdom of God; but they are cast out, and consigned to partake of the fruits of their labors or their works, which have been evil; and they drink the dregs of a bitter cup.

## Алма 41

- 1 Мөн эдүгээ, хүү минь, яригдсан сэргээлтийн талаар хэлэх зүйл надад байна; учир нь болгоогтун, зарим нь судруудыг гуйвуулсан, мөн энэ зүйлийн учир хол төөрөн одсон бөлгөө. Мөн чиний санаа түүнчлэн энэ зүйлийн талаар зовнисоор буйг би ухаарч байна. Гэвч болгоогтун, би үүнийг чамд тайлбарлах болно.
- 2 Би чамд хэлнэ, хүү минь, сэргээлтийн төлөвлөгөө Бурханы шударга ёсны дагуу зайлшгүй шаардагддаг; учир нь энэ бол бүх зүйл өөрсдийн зохист ёсоор сэргээгдэх нь зайлшгүй. Болгоогтун, Христийн амилалт хийгээд хүчний дагуу хүмүүний сүнс биедээ сэргээгдэх ёстой, мөн биеийн хэсэг болгон үүндээ сэргээгдэх нь зайлшгүй мөн шударга болой.
- 3 Мөн хүмүүн өөрсдийн ажлуудын дагуу шүүгдэх нь Бурханы шударга ёсны зайлшгүй шаардлага юм; мөн хэрэв энэ амьдралд тэдний ажлууд сайн байсан, мөн тэдний зүрх сэтгэлийн хүслүүд сайн байсан аваас, тэд түүнчлэн эцсийн өдөр сайн болох түүнд сэргээгдэх болно.
- 4 Мөн хэрэв тэдний ажлууд хилэнцэт аваас тэдгээр нь хилэнц болж өөрсдөд нь сэргээгдэх болно. Тиймийн тул, бүх зүйл өөрсдийн зохист ёсоор, зүйл бүр өөрийн унаган төрхөндөө сэргээгдэх болно—зуурдын байдал нь үхэшгүй байдалд, ялзрах чанар нь ялзаршгүйд босгогдож—Бурханы хаант улсыг өвлөн төгсгөлгүй аз жаргалд, эсвээс чөтгөрийн хаант улсыг өвлөн төгсгөлгүй зовлонд босгогдох нэг нь нэг талд нөгөө нь нөгөө талд байх болно—
- 5 Өөрийн аз жаргалыг хүссэнийхээ дагуу нэг нь аз жаргалд, эсвээс сайныг хүссэнийхээ дагуу сайнд; мөн нөгөө нь хилэнцийг хүссэнийхээ дагуу хилэнцэд босгогдоно; учир нь тэр бүхэл өдрийн турш хилэнцийг хийхээр хүссэнчлэн түүнчлэн шөнө ирэхэд тэрээр өөрийн шагнал болгон хилэнцийг авна.
- 6 Мөн тийн нөгөө талд ч үүний адил бөлгөө. Хэрэв тэр нүглүүдээ наманчилж, мөн өдрүүдийнхээ эцсийг хүртэл зөв шударгыг хүссэн бол, тэрчлэн тэрээр зөв шударгад шагнагдах болно.

## Alma 41

And now, my son, I have somewhat to say concerning the restoration of which has been spoken; for behold, some have wrested the scriptures, and have gone far astray because of this thing. And I perceive that thy mind has been worried also concerning this thing. But behold, I will explain it unto thee.

I say unto thee, my son, that the plan of restoration is requisite with the justice of God; for it is requisite that all things should be restored to their proper order. Behold, it is requisite and just, according to the power and resurrection of Christ, that the soul of man should be restored to its body, and that every part of the body should be restored to itself.

And it is requisite with the justice of God that men should be judged according to their works; and if their works were good in this life, and the desires of their hearts were good, that they should also, at the last day, be restored unto that which is good.

And if their works are evil they shall be restored unto them for evil. Therefore, all things shall be restored to their proper order, every thing to its natural frame—mortality raised to immortality, corruption to incorruption—raised to endless happiness to inherit the kingdom of God, or to endless misery to inherit the kingdom of the devil, the one on one hand, the other on the other—

The one raised to happiness according to his desires of happiness, or good according to his desires of good; and the other to evil according to his desires of evil; for as he has desired to do evil all the day long even so shall he have his reward of evil when the night cometh.

And so it is on the other hand. If he hath repented of his sins, and desired righteousness until the end of his days, even so he shall be rewarded unto righteousness.

- 7 Эдгээр нь Их Эзэнээр гэтэлгэгдэх тэд билээ; тийм ээ, эдгээр нь ангижруулагдаж, төгсгөлгүй шөнийн харанхуйгаас чөлөөлөгдөх тэд бөлгөө; мөн тийн тэд босно эсвэл унана; учир нь болгоогтун, тэд сайныг эсвэл мууг хийх эсэхээ өөрсдөө шүүх сонгогчид билээ.
- 8 Эдүгээ, Бурханы тогтоолууд нь хувиршгүй юм; тиймийн тул, хүссэн хэн боловч түүгээр алхаж мөн аврагдах тэрхүү зам бэлтгэгдсэн билээ.
- 9 Мөн эдүгээ болгоогтун, хүү минь, чи одоог хүртэл нүгэл үйлдэн аз туршсан, сургаалын хэсгүүд дээр Бурханы эсрэг үйлдэхээр дахин бүү аз турш.
- 10 Амилуулалтын талаар яригдсан учир чи нүглээс аз жаргалд сэргээгдэх болно гэж бүү бод. Болгоогтун, би чамд хэлнэ, ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй.
- 11 Мөн эдүгээ, хүү минь, төрөлхийн чанарт байгаа, бүхий л хүмүүн шаналлын гүн мөн алдсын хүлээсэнд байна өөрөөр миний эгэл чанарт буй гэж би хэлмээр байна; тэд дэлхийд Бурхангүй, мөн тэд Бурханы шинж чанарын эсрэг явсан билээ; тиймийн тул, тэд аз жаргалын шинж чанарын урвуу байдалд байдаг.
- 12 Мөн эдүгээ болгоогтун, сэргээлт гэдэг үгийн утга нь төрөлхийн шинж чанартай зүйлийг авч мөн төрөлхийн бус шинж чанарт үүнийг байрлуулдаг, эсвээс үүний төрөлх шинж чанарын нь эсрэг шинж чанарт үүнийг тавьдаг гэсэн үг үү
- 13 Ай, хүү минь, энэ нь нөхцөл бус юм; харин сэргээлт гэдэг үгийн утга нь хилэнцтийн хариуд хилэнцийг, эсвээс эгэлийн хариуд эгэлийг, эсвээс чөтгөрийнхийг чөтгөрийнхөд нь—сайн болох түүний хариуд сайныг; зөв шударгыг зөв шударга болох түүний хариуд; шударгыг шударга болох түүний хариуд; нигүүлсэнгүйг нигүүлсэнгүй болох түүний хариуд дахин буцаан авчирдаг бөлгөө.

These are they that are redeemed of the Lord; yea, these are they that are taken out, that are delivered from that endless night of darkness; and thus they stand or fall; for behold, they are their own judges, whether to do good or do evil.

Now, the decrees of God are unalterable; therefore, the way is prepared that whosoever will may walk therein and be saved.

And now behold, my son, do not risk one more offense against your God upon those points of doctrine, which ye have hitherto risked to commit sin.

Do not suppose, because it has been spoken concerning restoration, that ye shall be restored from sin to happiness. Behold, I say unto you, wickedness never was happiness.

And now, my son, all men that are in a state of nature, or I would say, in a carnal state, are in the gall of bitterness and in the bonds of iniquity; they are without God in the world, and they have gone contrary to the nature of God; therefore, they are in a state contrary to the nature of happiness.

And now behold, is the meaning of the word restoration to take a thing of a natural state and place it in an unnatural state, or to place it in a state opposite to its nature?

O, my son, this is not the case; but the meaning of the word restoration is to bring back again evil for evil, or carnal for carnal, or devilish for devilish—good for that which is good; righteous for that which is righteous; just for that which is just; merciful for that which is merciful.

14 Тиймийн тул, хүү минь, өөрийн ах дүүстээ нигүүлсэнгүй байхаа мэд; шударгаар харьц, зөв шударгаар шүү, мөн үргэлж сайныг үйлд; мөн хэрэв чи эдгээр бүх зүйлийг хийвэл чи шагналаа хүлээн авах болно; тийм ээ, чамд нигүүлсэл буцаан сэргээгдэх болно; чамд шударга ёс бас буцаан сэргээгдэх болно; чамд зөв шударга шүүлт буцаан сэргээгдэх болно; мөн чамд сайн нь буцаан шагнагдах болно.

15 Учир нь чиний гадагш илгээсэн нь чамд буцаж ирнэ, мөн сэргээгдэх болно; тиймийн тул, сэргээлт гэдэг үг нүгэлтнийг илүү бүрэн дүүрнээр буруутгаж, мөн түүнийг огтхон ч үл зөвтгөх бөлгөө.

Therefore, my son, see that you are merciful unto your brethren; deal justly, judge righteously, and do good continually; and if ye do all these things then shall ye receive your reward; yea, ye shall have mercy restored unto you again; ye shall have justice restored unto you again; ye shall have a righteous judgment restored unto you again; and ye shall have good rewarded unto you again.

For that which ye do send out shall return unto you again, and be restored; therefore, the word restoration more fully condemneth the sinner, and justifieth him not at all.

## Алма 42

- 1 Мөн эдүгээ, хүү минь, чиний санааг зовоож буй зарим нэг илүү зүйл байгааг би ухаарч байна, чиний ойлгохгүй байгаа тэр нь—нүгэлтнийг шийтгэхэд Бурханы шударга ёсны талаар юм; учир нь нүгэлтэн зовлонгийн байдалд хуваарилагдах нь шударга бус хэмээн бодохыг чи оролдож байна.
- 2 Эдүгээ болгоогтун, хүү минь, би энэ зүйлийг чамд тайлбарлах болно. Учир нь болгоогтун, Их Эзэн Бурхан өөрсдийг нь гарган авсан газрыг хагалуулахаар бидний анхны эцэг эхийг Еденийн цэцэрлэгээс хөөсний дараа—тийм ээ, тэрээр хүмүүнийг татан гаргаж, мөн тэрээр Еденийн цэцэрлэгийн дорнод талд херубим, мөн зүг бүрд эргэх галт илдийг, амьдралын модыг хамгаалуулахаар байрлуулжээ—
- 3 Эдүгээ, хүмүүн Бурханы адил сайн ба муут мэддэг болсныг бид харав; мөн тэрээр гараа сунган, мөн түүнчлэн амьдралын модноос авч, мөн идээд мөн үүрд амьдрах вий хэмээн, Их Эзэн Бурхан херубимыг мөн галт илдийг, тэрээр уг жимсийг хүртэхгүй байхын тулд байрлуулжээ—
- 4 Мөн тийн хүмүүнд наманчлах цаг, тийм ээ, сорилтын цаг, наманчлах хийгээд Бурханд үйлчлэх цаг олгогдсоныг бид харав.
- 5 Учир нь болгоогтун, хэрэв Адам тэр даруй гараа сунган, мөн амьдралын модныхоос хуртсэн бол, Бурханы үгийн дагуу тэр, наманчлах хугацаагүйгээр үүрд амьдрах байсан; тийм ээ, мөн түүнчлэн Бурханы үг хүчингүй болж, мөн авралын агуу төлөвлөгөө бүтэхгүй байсан билээ.
- 6 Гэвч болгоогтун, үхэх нь хүмүүнд тохоогдсон юм—тиймийн тул, тэд амьдралын модноос тусгаарлагдсанчлан тэд газрын гадаргуугаас тусгаарлагдах болно—мөн хүмүүн үүрд төөрөлдөж, тийм ээ, тэд унасан хүмүүн болжээ.
- 7 Мөн эдүгээ, чи үүгээр бидний анхны эцэг эх биеийн хийгээд сүнслэг байдлын аль алианаар нь Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсаныг харав; мөн тийн тэд, өөрсдийн хүсэл тааллын эрхшээлийг дагагчид болсныг бид харав.
- 8 Эдүгээ болгоогтун, хүмүүн энэ биеийн үхлээс буцаагдах нь зохистой байсангүй, учир нь тэгэх нь аз жаргалын агуу төлөвлөгөөг устгах байв.

## Alma 42

And now, my son, I perceive there is somewhat more which doth worry your mind, which ye cannot understand—which is concerning the justice of God in the punishment of the sinner; for ye do try to suppose that it is injustice that the sinner should be consigned to a state of misery.

Now behold, my son, I will explain this thing unto thee. For behold, after the Lord God sent our first parents forth from the garden of Eden, to till the ground, from whence they were taken—yea, he drew out the man, and he placed at the east end of the garden of Eden, cherubim, and a flaming sword which turned every way, to keep the tree of life—

Now, we see that the man had become as God, knowing good and evil; and lest he should put forth his hand, and take also of the tree of life, and eat and live forever, the Lord God placed cherubim and the flaming sword, that he should not partake of the fruit—

And thus we see, that there was a time granted unto man to repent, yea, a probationary time, a time to repent and serve God.

For behold, if Adam had put forth his hand immediately, and partaken of the tree of life, he would have lived forever, according to the word of God, having no space for repentance; yea, and also the word of God would have been void, and the great plan of salvation would have been frustrated.

But behold, it was appointed unto man to die—therefore, as they were cut off from the tree of life they should be cut off from the face of the earth—and man became lost forever, yea, they became fallen man.

And now, ye see by this that our first parents were cut off both temporally and spiritually from the presence of the Lord; and thus we see they became subjects to follow after their own will.

Now behold, it was not expedient that man should be reclaimed from this temporal death, for that would destroy the great plan of happiness.

- 9 Тиймийн тул, сүнс хэзээ ч үхэж болдоггүйн учир, мөн уналт нь бүх хүн төрөлхтний дээр биеийнхтэй нэгэн адил сүнсний үхлийг ч авчирсан буюу, тэгснээр тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан билээ, хүн төрөлхтөн энэхүү сүнсний үхлээс буцаагдах шаардлагатай байв.
- 10 Тиймийн тул, тэд төрөлхөөсөө эгэл, тачаангуй, чөтгөр мэт болж, энэхүү сорилтын байдал нь тэдний хувьд бэлтгэх байдал болсон ажгуу; энэ нь бэлтгэлийн байдал болсон билээ.
- 11 Мөн эдүгээ санагтун, хүү минь, хэрэв гэтэлгэлийн энэ төлөвлөгөө байгаагүй аваас (үүнийг эс тооцвол) үхсэн даруйдаа тэдний сүнс, Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан учир зовлонг байх байсан.
- 12 Мөн эдүгээ, хүмүүн өөрийнхөө дуулгаваргүйн учир өөрийнхөө дээр авчирсан тэрхүү уналтын байдлаас хүмүүсийг буцаах ямар ч арга байхгүй байв;
- 13 Тиймийн тул, шударга ёсны дагуу, гэтэлгэлийн төлөвлөгөө нь энэхүү сорилтын байдал тийм ээ, энэ бэлтгэлийн байдал дахь хүмүүний наманчлалын нөхцөлөөс бусдаар бол үйлчилж чадахгүй; учир нь эдгээр нөхцөлүүдийг хангахаас бусдаар, шударга ёсны ажлыг устгахгүйгээр нигүүлсэл үйлчилж чадахгүй. Эдүгээ шударга ёсны ажил устгагдах учиргүй; хэрэв тэгвэл, Бурхан нь Бурхан байхаа болих сон.
- 14 Мөн бүх хүн төрөлхтөн унасныг, мөн тэд шударга ёсны хяналтан дор байсныг бид ийн харав; тийм ээ, тэднийг үүрд түүний дэргэдээс тусгаарлагдахаар хуваарилагдсан Бурханы шударга ёсных буюу.
- 15 Мөн эдүгээ, нигүүлслийн төлөвлөгөө нь цагаатгал хийгдэхгүйгээр улиран тохиогдох боломжгүй; тиймийн тул Бурхан нь төгс, шударга Бурхан, мөн түүнчлэн нигүүлсэнгүй Бурхан байж болохын тулд нигүүлслийн төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр, шударга ёсны шаардлагыг хангахаар Бурхан өөрөө дэлхийн нүглийн төлөө цагаатгалыг нөхөн төлдөг.
- 16 Эдүгээ, түүнчлэн сүнсний амьдралын адил мөнхийн байх аз жаргалын төлөвлөгөөний эсрэг тавигдсан, сүнсний амьдралын адил мөнхийн байх шийтгэлгүй аваас наманчлал ирж чадахгүй.

Therefore, as the soul could never die, and the fall had brought upon all mankind a spiritual death as well as a temporal, that is, they were cut off from the presence of the Lord, it was expedient that mankind should be reclaimed from this spiritual death.

Therefore, as they had become carnal, sensual, and devilish, by nature, this probationary state became a state for them to prepare; it became a preparatory state.

And now remember, my son, if it were not for the plan of redemption, (laying it aside) as soon as they were dead their souls were miserable, being cut off from the presence of the Lord.

And now, there was no means to reclaim men from this fallen state, which man had brought upon himself because of his own disobedience;

Therefore, according to justice, the plan of redemption could not be brought about, only on conditions of repentance of men in this probationary state, yea, this preparatory state; for except it were for these conditions, mercy could not take effect except it should destroy the work of justice. Now the work of justice could not be destroyed; if so, God would cease to be God.

And thus we see that all mankind were fallen, and they were in the grasp of justice; yea, the justice of God, which consigned them forever to be cut off from his presence.

And now, the plan of mercy could not be brought about except an atonement should be made; therefore God himself atoneth for the sins of the world, to bring about the plan of mercy, to appease the demands of justice, that God might be a perfect, just God, and a merciful God also.

Now, repentance could not come unto men except there were a punishment, which also was eternal as the life of the soul should be, affixed opposite to the plan of happiness, which was as eternal also as the life of the soul.

17 Эдүгээ, нүгэл үйлддэггүй аваас хүмүүн яаж наманчлах билээ? Хууль үгүй бол тэр яаж нүгэл үйлдэж чадах сан билээ? Шийтгэл үгүй бол хууль хэрхэн байж чадах билээ

18 Эдүгээ, шийтгэл нь тогтоогдсон, мөн хүмүүнд ухамсрын гэмшлийг авчирсан тэрхүү шударга хууль өгөгдсөн билээ.

19 Эдүгээ, хэрэв хууль өгөгдөөгүй бол—хэрэв хүмүүн аллага үйлдсэн бол үхэх ёстой хэмээн—тэрээр хэрэв тэр аллага үйлдвэл үхнэ хэмээн айх гэж үү

20 Мөн түүнчлэн, хэрэв нүглийн эсрэг хууль өгөгдөөгүй сэн бол хүмүүн нь нүгэл үйлдэхээс айхгүй байх сан.

21 Мөн хэрэв хууль өгөгдөөгүй сэн бол, хэрэв хүмүүн нь нүгэл үйлдсэн бол шударга ёс эсвээс нигүүлсэл юу хийж чадах вэ? Учир нь тэдгээр нь тэр хүний дээр эрхгүй байх болно.

22 Гэвч хууль өгөгдсөн, мөн шийтгэл нь тогтоогдсон, мөн наманчлал олгогдсон юм; нигүүлсэл нь наманчлалыг шаардана; өөрөөр бол, шударга ёс нь уг хүнийг шаардаж, мөн шударга ёс хуулийг хэрэгжүүлж, мөн хууль нь шийтгэлийг оноодог; хэрвээ тийм бус аваас, шударга ёсны ажлууд устгагдаж, мөн Бурхан нь Бурхан байхаа болих сон.

23 Гэвч Бурхан Бурхан байхаа болихгүй, мөн нигүүлсэл нь гэмшигчийг шаарддаг, мөн нигүүлсэл нь цагаатгалын учир ирдэг; мөн цагаатгал нь нас барагсдын амилуулалтыг улируулан тохиолгодог; мөн нас барагсдын амилуулалт нь хүмүүнийг Бурханы дэргэд буцаан авчирдаг; мөн ийн тэд, өөрсдийн хийсний дагуу, хууль болоод шударга ёсны дагуу шүүгдэхийн тулд түүний дэргэд байхаар сэргээгддэг.

24 Учир нь болгоогтун, шударга ёс нь өөрийн бүх шаардлагуудыг гүйцээж, мөн түүнчлэн нигүүлсэл нь өөрийн болох бүгдийг өөртөө харьяалуулдаг; мөн тийн, үнэнээр гэмшигчээс өөр хэн ч аврагдахгүй.

25 Юу, чи нигүүлсэл нь шударга ёсыг дээрэмдэж болно хэмээн бодно уу? Би чамд хэлнэ, Үгүй; огтхон ч тийм бус. Хэрэв тийм аваас, Бурхан нь Бурхан байхаа болих сон.

Now, how could a man repent except he should sin? How could he sin if there was no law? How could there be a law save there was a punishment?

Now, there was a punishment affixed, and a just law given, which brought remorse of conscience unto man.

Now, if there was no law given—if a man murdered he should die—would he be afraid he would die if he should murder?

And also, if there was no law given against sin men would not be afraid to sin.

And if there was no law given, if men sinned what could justice do, or mercy either, for they would have no claim upon the creature?

But there is a law given, and a punishment affixed, and a repentance granted; which repentance, mercy claimeth; otherwise, justice claimeth the creature and executeth the law, and the law inflicteth the punishment; if not so, the works of justice would be destroyed, and God would cease to be God.

But God ceaseth not to be God, and mercy claimeth the penitent, and mercy cometh because of the atonement; and the atonement bringeth to pass the resurrection of the dead; and the resurrection of the dead bringeth back men into the presence of God; and thus they are restored into his presence, to be judged according to their works, according to the law and justice.

For behold, justice exerciseth all his demands, and also mercy claimeth all which is her own; and thus, none but the truly penitent are saved.

What, do ye suppose that mercy can rob justice? I say unto you, Nay; not one whit. If so, God would cease to be God.

- 26 Мөн тийн Бурхан дэлхийн үүслээс бэлтгэгдсэн өөрийн тэр агуу их хийгээд мөнхийн зорилгуудыг авчирдаг. Мөн тийн хүмүүний аврал хийгээд гэтэлгэл нь, мөн түүнчлэн тэдний устгал мөн зовлон нь ирдэг.
- 27 Тиймийн тул, ай хүү минь, ирэх хэн боловч ирж мөн амьдралын уснаас чөлөөтэйгөөр хүртэж болно; мөн ирэхгүй хэн боловч мөнхүү тэр нь ирэхээр үл албадуулагддаг; гэвч эцсийн өдөр хийснийхээ дагуу түүнд сэргээгдэх болно.
- 28 Хэрэв тэр хилэнц үйлдэхийг хүссэн, мөн өөрийн өдрүүдэд наманчлаагүй аваас, болгоогтун, хилэнц нь Бурханы сэргээлтийн дагуу түүнд хийгдэх болно.
- 29 Мөн эдүгээ, хүү минь, чамайг эдгээр зүйл дахин бүү зовоогоосой, мөн зөвхөн доош наманчлалд авчрах зовлонгоор нүглүүд чинь чамайг зовоогоосой хэмээн би хүснэ.
- 30 Ай хүү минь, чамайг Бурханы шударга ёсыг дахин бүү үгүйсгээсэй хэмээн би хүснэ. Бурханы шударга ёсыг үгүйсгээд нүглүүдээ хаацайлахыг огтхон ч бүү хичээ; харин Бурханы шударга ёс, мөн түүний нигүүлсэл хийгээд тэсвэр нь зүрх сэтгэлд чинь бүрэн дүүрнээр нөлөөлөхийг зөвшөөр чи; мөн энэ нь чамайг доош тоос шороо лугаа адил даруу байдалд авчрахыг зөвшөөр.
- 31 Мөн эдүгээ, Ай хүү минь, чи энэ хүмүүст үгийг номлохоор Бурханаар дуудагдсан билээ. Мөн эдүгээ, хүү минь, чи өөрийн замаар явж, бодгалиудыг наманчлалд авчирч болохын тулд, нигүүлслийн агуу төлөвлөгөөнд тэд харьяалагдаж болохын тулд үгийг үнэнээр мөн чандаар тунхагла. Мөн бүр миний үгсийн дагуу Бурхан чамд соёрхох болтугай. Амен.

And thus God bringeth about his great and eternal purposes, which were prepared from the foundation of the world. And thus cometh about the salvation and the redemption of men, and also their destruction and misery.

Therefore, O my son, whosoever will come may come and partake of the waters of life freely; and whosoever will not come the same is not compelled to come; but in the last day it shall be restored unto him according to his deeds.

If he has desired to do evil, and has not repented in his days, behold, evil shall be done unto him, according to the restoration of God.

And now, my son, I desire that ye should let these things trouble you no more, and only let your sins trouble you, with that trouble which shall bring you down unto repentance.

O my son, I desire that ye should deny the justice of God no more. Do not endeavor to excuse yourself in the least point because of your sins, by denying the justice of God; but do you let the justice of God, and his mercy, and his long-suffering have full sway in your heart; and let it bring you down to the dust in humility.

And now, O my son, ye are called of God to preach the word unto this people. And now, my son, go thy way, declare the word with truth and soberness, that thou mayest bring souls unto repentance, that the great plan of mercy may have claim upon them. And may God grant unto you even according to my words. Amen.



## Алма 43

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Алмагийн хөвгүүд хүмүүсийн дунд Бурханы үгийг тунхаглахаар явцгаав. Мөн Алма, түүнчлэн, өөрөө, амарч үл чадан түүнчлэн явав.
- 2 Эдүгээ тэд бошиглолын мөн илчлэлтийн суу билгийн дагуу үгийг мөн үнэнийг номлож байсан гэдгээс өөрийг бид тэдний номлолын талаар дахин ярихгүй; мөн тэд өөрсдийн дуудагдсан Бурханы ариун жаягийн дагуу номлоцгоов.
- 3 Мөн эдүгээ би шүүгчдийн засаглалын арван найм дахь онд леменчүүд мөн нифайчуудын хооронд болсон дайнуудын шастирт эргэн оръё.
- 4 Учир нь болгоогтун, улиран тохиох дор зорамчууд леменчүүд болов; тиймийн тул, арван найм дахь оны эхэнд леменчүүд тэдний дээр ирж буйг Нифайн хүмүүс харав; тиймийн тул тэд дайны бэлтгэл хийв; тийм ээ, тэд өөрсдийн их цэргийг Жершоны нутагт нэгтгэн цуглуулав.
- 5 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд мянга мянгаараа ирэв; мөн тэд зорамчуудын газар нутаг болох Антионум нутагт орж ирэв; мөн Зерахемна гэж нэрлэгдэх нэг хүн тэдний удирдагч байв.
- 6 Мөн эдүгээ амалекайчууд леменчүүдийг бодвол илүү хэрцгий мөн аллагад илүү дур сонирхолтой байв, тиймийн тул Зерахемна леменчүүдийн дээрх ерөнхий ахлагчдыг томилов, мөн тэд бүгдээрээ Амалекайчууд мөн зорамчууд байв.
- 7 Эдүгээ тэр үүнийг нифайчуудад хандах үзэн ядах үзлийг нь хадгалж болохын тулд, мөн өөрийнхөө санааг гүйцэлдүүлэн тэднийг эрхшээлдээ оруулахаар хийсэн ажгуу.
- 8 Учир нь болгоогтун түүний санаа нь леменчүүдийг нифайчуудын эсрэг уурлуулахаар өдөөн хатгах явдал байв; мөн ингэснээр тэр тэдний дээр их хүчийг хууль бусаар эзэлж болохын тулд, мөн нифайчуудыг боолчлолд оруулснаар тэдний дээр хүчийг олж болохын тулд тэрээр үүнийг хийжээ.

## Alma 43

And now it came to pass that the sons of Alma did go forth among the people, to declare the word unto them. And Alma, also, himself, could not rest, and he also went forth.

Now we shall say no more concerning their preaching, except that they preached the word, and the truth, according to the spirit of prophecy and revelation; and they preached after the holy order of God by which they were called.

And now I return to an account of the wars between the Nephites and the Lamanites, in the eighteenth year of the reign of the judges.

For behold, it came to pass that the Zoramites became Lamanites; therefore, in the commencement of the eighteenth year the people of the Nephites saw that the Lamanites were coming upon them; therefore they made preparations for war; yea, they gathered together their armies in the land of Jershon.

And it came to pass that the Lamanites came with their thousands; and they came into the land of Antionum, which is the land of the Zoramites; and a man by the name of Zerahemnah was their leader.

And now, as the Amalekites were of a more wicked and murderous disposition than the Lamanites were, in and of themselves, therefore, Zerahemnah appointed chief captains over the Lamanites, and they were all Amalekites and Zoramites.

Now this he did that he might preserve their hatred towards the Nephites, that he might bring them into subjection to the accomplishment of his designs.

For behold, his designs were to stir up the Lamanites to anger against the Nephites; this he did that he might usurp great power over them, and also that he might gain power over the Nephites by bringing them into bondage.

- 9 Мөн эдүгээ дайснуудынхаа гарт орохоос хамгаалж болохын тулд нифайчууд өөрсдийн газар нутаг, өөрсдийн орон байр, өөрсдийн эхнэр болоод хүүхдүүдийг дэмжих нь тэдний санаа байв; мөн түүнчлэн тэд хүслийнхээ дагуу Бурханыг шүтэн биширч болохын тулд өөрсдийн эрх хийгээд өөрсдийн боломжууд, тийм ээ, мөн түүнчлэн өөрсдийн эрх чөлөөг хадгалан үлдээж болохын тулд болой.
- 10 Учир нь хэрвээ тэд леменчүүдийн гарт орох юм бол, үнэн болон амьд Бурханыг, сүнсээр болон үнэнээр Бурханыг бишрэн шүтэх хэнийг ч гэсэн леменчүүд устгах болно гэдгийг мэдсэн бөлгөө.
- 11 Тийм ээ, мөн Аммоны хүмүүс гэж нэрлэгдсэн Антай-Нифай-Лихайн хүмүүс болох ах дүүсийнхээ эсрэг леменчүүд үлэмжийн үзэн ядалтаар ханддагийг түүнчлэн тэд мэдсэн буюу—мөн Аммоны хүмүүс зэр зэвсгээ агсахгүй, тийм ээ, тэд гэрээнд орсон мөн тэд үүнийгээ зөрчихгүй байв—тиймийн тул, хэрэв тэд леменчүүдийн гарт орвол тэд устгагдах байлаа.
- 12 Мөн тэд устгагдахыг нифайчууд тэвчихгүй байв; тиймийн тул тэдэнд өвлөх нутгийг тэд өгсөн бөлгөө.
- 13 Мөн Аммоны хүмүүс өөрсдийнхөө хөрөнгөний ихээхэн хэсгийг их цэргийг нь дэмжихээр нифайчуудад өгсөн байв; мөн тийн нифайчуудаас тэрсэлсэн, амалекайчууд мөн зорамчууд болон Ноагийн санваартнуудын үр удам болох тэднээс, мөн Лемен мөн Лемүел, бас Ишмэилийн хөвгүүдээс бүрдсэн Леменчүүдийн эсрэг нифайчууд дангаараа сөрөн зогсохоор албадуулагдав.
- 14 Эдүгээ тэдний үр удам нифайчуудын адил бараг тийм олон байв; мөн тийн нифайчууд ах дүүстэйгээ цус асгарах хүртэл тулалдах шаардлагатай болсон ажгуу.
- 15 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг Антионумын газар нутаг дээр цугларсан учир, болгоогтун, нифайчуудын их цэрэг тэдэнтэй Жершоны газар нутаг дээр уулзахаар бэлтгэсэн байв.

And now the design of the Nephites was to support their lands, and their houses, and their wives, and their children, that they might preserve them from the hands of their enemies; and also that they might preserve their rights and their privileges, yea, and also their liberty, that they might worship God according to their desires.

For they knew that if they should fall into the hands of the Lamanites, that whosoever should worship God in spirit and in truth, the true and the living God, the Lamanites would destroy.

Yea, and they also knew the extreme hatred of the Lamanites towards their brethren, who were the people of Anti-Nephi-Lehi, who were called the people of Ammon—and they would not take up arms, yea, they had entered into a covenant and they would not break it—therefore, if they should fall into the hands of the Lamanites they would be destroyed.

And the Nephites would not suffer that they should be destroyed; therefore they gave them lands for their inheritance.

And the people of Ammon did give unto the Nephites a large portion of their substance to support their armies; and thus the Nephites were compelled, alone, to withstand against the Lamanites, who were a compound of Laman and Lemuel, and the sons of Ishmael, and all those who had dissented from the Nephites, who were Amalekites and Zoramites, and the descendants of the priests of Noah.

Now those descendants were as numerous, nearly, as were the Nephites; and thus the Nephites were obliged to contend with their brethren, even unto bloodshed.

And it came to pass as the armies of the Lamanites had gathered together in the land of Antionum, behold, the armies of the Nephites were prepared to meet them in the land of Jershon.

- 16 Эдүгээ нифайчуудын удирдагч өөрөөр хэлбэл нифайчуудын дээр ерөнхий ахлагчаар томилогдсон хүн—эдүгээ ерөнхий ахмад нь нифайчуудын бүх цэргийн удирдлагыг авчээ—мөн түүний нэрийг Моронай гэдэг байв;
- 17 Мөн Моронай дайнуудынхаа бүх удирдлага мөн засаглалыг авав. Мөн тэр нифайчуудын бүх цэргийн ерөнхий ахмадаар томилогдохдоо дөнгөж хорин таван настай байв.
- 18 Мөнхүү улиран тохиох дор тэр Жершоны хил дээр леменчүүдтэй тулгарч, мөн түүний хүмүүс сэлэм, мөн илд, мөн дайны бүх төрлийн зэвсгээр зэвсэглэсэн байв.
- 19 Мөн леменчүүдийн их цэрэг Нифайн хүмүүсийг эсвээс Моронай, өөрийн хүмүүсийг цээжний хуяг мөн гарын хаалт, тийм ээ, мөн түүнчлэн толгойгоо хамгаалах дуулга өмсгөж, мөн түүнчлэн тэднийг зузаан хувцсаар хувцаслаж бэлтгэснийг хараад—
- 20 Эдүгээ Зерахемнагийн их цэрэг тийм зүйлээр огт бэлтгэгдээгүй байв; тэдэнд зөвхөн сэлэм, илднүүд, мөн нум, сумнууд, чулуу мөн дүүгүүрүүд нь байв; мөн тэд хэвлийн тус газраасаа унжуулсан арьснаас өөр юмгүй нүцгэн байв; тийм ээ, зорамчууд мөн ама-лекайчуудаас бусад нь бүгд нүцгэн байв;
- 21 Гэвч тэд цээжний хуягтай бас бамбайгаар хуягласангүй—тиймийн тул, тэд тэдний хуяг дуулгынх нь учир, тэдний тоо нифайчуудынхаас илүү олон байсан ч нифайчуудын их цэргээс үлэмж айв.
- 22 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор тэд Жершоны хил дээр нифайчуудын эсрэг довтолж зүрхэлсэнгүй; тиймийн тул тэд Мантай нутагт ирж мөн уг нутгийг эзэмшилдээ авч болохын тулд тэд Антионумын нутгаас гарч аглаг буйд тийш одоод, мөн аглаг буйдын дотор тойрон явж, Сидон голын эх рүү очив; учир нь тэд Моронайн их цэрэг тэдний хааш одсоныг мэднэ хэмээн бодсонгүй ажээ.

Now, the leader of the Nephites, or the man who had been appointed to be the chief captain over the Nephites—now the chief captain took the command of all the armies of the Nephites—and his name was Moroni;

And Moroni took all the command, and the government of their wars. And he was only twenty and five years old when he was appointed chief captain over the armies of the Nephites.

And it came to pass that he met the Lamanites in the borders of Jershon, and his people were armed with swords, and with cimeters, and all manner of weapons of war.

And when the armies of the Lamanites saw that the people of Nephi, or that Moroni, had prepared his people with breastplates and with arm-shields, yea, and also shields to defend their heads, and also they were dressed with thick clothing—

Now the army of Zerahemnah was not prepared with any such thing; they had only their swords and their cimeters, their bows and their arrows, their stones and their slings; and they were naked, save it were a skin which was girded about their loins; yea, all were naked, save it were the Zoramites and the Amalekites;

But they were not armed with breastplates, nor shields—therefore, they were exceedingly afraid of the armies of the Nephites because of their armor, notwithstanding their number being so much greater than the Nephites.

Behold, now it came to pass that they durst not come against the Nephites in the borders of Jershon; therefore they departed out of the land of Antionum into the wilderness, and took their journey round about in the wilderness, away by the head of the river Sidon, that they might come into the land of Manti and take possession of the land; for they did not suppose that the armies of Moroni would know whither they had gone.

- 23 Гэвч улиран тохиох дор, тэднийг аглаг буйдад од-могц тэдний буудлыг тандуулахаар Моронай тур-шуулууд илгээсэн байжээ; мөн Моронай түүнчлэн, Алмагийн бошиглолуудын тухай мэдсэн учир, хэдэн эрсийг түүнд илгээж, нифайчуудын их цэрэг лемен-чүүдээс өөрсдийгөө хамгаалахын тулд хааш явахыг Их Эзэнээс лавлахыг түүнээс хүсэв.
- 24 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний үг Алмад ирж, мөн леменчүүдийн их цэрэг аглаг буйдад, тэд Мантай нутагт дайран орж болно хэмээн, тэд уг хү-мүүсийн арай дорой хэсэг рүү дайралтыг эхэлж бо-лохын тулд тойрон явж байгааг Моронайн элч нарт Алма мэдээлэв. Мөн тэдгээр элчүүд одож мөн Моронайд мэдээг хүргэв.
- 25 Эдүгээ Моронай, леменчүүдийн хэсэг уг нутагт ирж мөн хотыг эзэмшилдээ авах вий хэмээн их цэр-гийнхээ нэг хэсгийг Жершоны нутагт орхиод, цэр-гийнхээ үлдсэн хэсгийг авч мөн Мантай нутагт жаг-сан очив.
- 26 Мөн тэрээр уг нутгийн тэр хэсгийн бүх хүмүүсийг леменчүүдийн эсрэг тулалдахаар, газар нутгаа мөн улс орноо, эрх хийгээд эрх чөлөөгөө хамгаалахаар цугларцгаах болгов; тиймийн тул тэд леменчүүдийн ирэх цагт бэлтгэгдсэн байв.
- 27 Мөнхүү улиран тохиох дор Моронай их цэргээ Сидон голын эргийн ойролцоох, аглаг буйд дахь Сидон голын өрнөд эрэг дээрх тэр хөндийд нуутгах болгов.
- 28 Мөн Моронай эргэн тойрондоо туршуулуудыг леменчүүдийн буудал хэзээ ирэхийг мэдэж болохын тулд байрлуулав.
- 29 Мөн эдүгээ, тэд бүх нутаг даяар өөрсдөдөө хаант улсыг байгуулж болохын тулд тэднийг харьяатаа болгон мөн боолчлолд оруулах нь эсвээс ах дүүсээ устгах нь тэдний зорилго, леменчүүдийн зорилго болохыг Моронай мэдсэн учир;

But it came to pass, as soon as they had departed into the wilderness Moroni sent spies into the wilderness to watch their camp; and Moroni, also, knowing of the prophecies of Alma, sent certain men unto him, desiring him that he should inquire of the Lord whither the armies of the Nephites should go to defend themselves against the Lamanites.

And it came to pass that the word of the Lord came unto Alma, and Alma informed the messengers of Moroni, that the armies of the Lamanites were marching round about in the wilderness, that they might come over into the land of Manti, that they might commence an attack upon the weaker part of the people. And those messengers went and delivered the message unto Moroni.

Now Moroni, leaving a part of his army in the land of Jershon, lest by any means a part of the Lamanites should come into that land and take possession of the city, took the remaining part of his army and marched over into the land of Manti.

And he caused that all the people in that quarter of the land should gather themselves together to battle against the Lamanites, to defend their lands and their country, their rights and their liberties; therefore they were prepared against the time of the coming of the Lamanites.

And it came to pass that Moroni caused that his army should be secreted in the valley which was near the bank of the river Sidon, which was on the west of the river Sidon in the wilderness.

And Moroni placed spies round about, that he might know when the camp of the Lamanites should come.

And now, as Moroni knew the intention of the Lamanites, that it was their intention to destroy their brethren, or to subject them and bring them into bondage that they might establish a kingdom unto themselves over all the land;

30 Мөн түүнчлэн тэрээр өөрсдийн нутаг, өөрсдийн эрх чөлөө, мөн өөрсдийн сүмийг хамгаалах нь нифайчуудын цорын ганц хүсэл байсныг мэдсэн учир, тиймийн тул тэрээр зальт аргаар өөрсдийгөө хамгаалах нь нүгэл биш хэмээн бодож; тиймийн тул тэр туршуулуудаасаа леменчүүд аль замаар явах гэж буйг олж мэдсэн бөлгөө.

31 Тиймийн тул тэрээр цэргээ хуваан мөн нэг хэсгийг нь уг хөндийд авчирч, мөн тэднийг Рипла толгойн дорнодод, мөн урд талд нь нуужээ;

32 Мөн үлдсэнийг нь тэрээр өрнөдөд байх хөндийд, Сидон голын баруун талд, мөн тийн Мантай нутгийн хязгаарыг хүртэл далдалжээ.

33 Мөн тийн тэрээр хүссэнийхээ дагуу их цэргээ байрлуулсан учир, тэр тэдэнтэй тулахаар бэлтгэсэн байв.

34 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Моронайн цэргийн нэг хэсэг нь нуугдсан нөгөөх толгойн хойд талд ирэв.

35 Мөн леменчүүд Рипла толгойг өнгөрч мөн уг хөндийд орж мөн Сидон голыг гаталж эхэлсэн учир, толгойн урд нуугдаж байсан Лихай гэгчээр удирдуулсан цэргүүд мөн тэрээр өөрийн цэргийг урагш удирдаж мөн леменчүүдийг дорнодод араар нь ороон бүслэв.

36 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудыг тэдний зүг араас нь ирж буйг леменчүүд хармагцаа, тэд эргэж мөн Лихайн цэргүүдтэй тулалдаж эхлэв.

37 Мөн хоёр тал аль аль нь алалдах тулааныг эхлэв. Харин энэ нь леменчүүдийн хувьд илүү айдас төрүүлэм байв. Учир нь нифайчуудын сэлэм мөн илднүүдэд, бараг цохилт болгон нь үхлийг авчрах хүнд цавчилтуудад тэдний нүцгэн биес өртсөн болой.

38 Нөгөө талаас нь үзвэл нифайчуудын дунд энд тэнд илдэнд өртөж мөн цус алдсанаас хааяа нэг хүн унав, тэд биенийхээ амин газруудыг халхалсан, өөрөөр хэлбэл илүү амин газрууд нь леменчүүдийн цохилтоос цээжний хуягаар мөн гарын хаалтаар, мөн дуулгаар халхлагдсан байлаа; мөн тийн нифайчууд леменчүүдийн дунд үхлийг үргэлжлүүлэн тарьж байв.

And he also knowing that it was the only desire of the Nephites to preserve their lands, and their liberty, and their church, therefore he thought it no sin that he should defend them by stratagem; therefore, he found by his spies which course the Lamanites were to take.

Therefore, he divided his army and brought a part over into the valley, and concealed them on the east, and on the south of the hill Riplah;

And the remainder he concealed in the west valley, on the west of the river Sidon, and so down into the borders of the land Manti.

And thus having placed his army according to his desire, he was prepared to meet them.

And it came to pass that the Lamanites came up on the north of the hill, where a part of the army of Moroni was concealed.

And as the Lamanites had passed the hill Riplah, and came into the valley, and began to cross the river Sidon, the army which was concealed on the south of the hill, which was led by a man whose name was Lehi, and he led his army forth and encircled the Lamanites about on the east in their rear.

And it came to pass that the Lamanites, when they saw the Nephites coming upon them in their rear, turned them about and began to contend with the army of Lehi.

And the work of death commenced on both sides, but it was more dreadful on the part of the Lamanites, for their nakedness was exposed to the heavy blows of the Nephites with their swords and their cimeters, which brought death almost at every stroke.

While on the other hand, there was now and then a man fell among the Nephites, by their swords and the loss of blood, they being shielded from the more vital parts of the body, or the more vital parts of the body being shielded from the strokes of the Lamanites, by their breastplates, and their armshields, and their headplates; and thus the Nephites did carry on the work of death among the Lamanites.

- 39 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд, тэдний дундах агуу устгалын учир, бүр тэд Сидон голын зүг зугтаж эхэлглээ айж эхлэв.
- 40 Мөн тэд Лихай болон түүний эрчүүдээр мөрдөгдөж байв; мөн тэд Лихайгаар Сидоны ус уруу туугдаж, мөн тэд Сидоны усыг гатлав. Мөн Лихай тэд гатлахгүйн тулд их цэргээ Сидон голын эрэг дээр авч үлдэв.
- 41 Мөнхүү улиран тохиох дор Моронай мөн түүний их цэрэг уг хөндийд, Сидон голын нөгөө эрэг дээр леменчүүдтэй тулж мөн тэдний дээрээс дайран орж мөн тэднийг алж эхлэв.
- 42 Мөн леменчүүд тэдний өмнө Мантай нутгийг чиглэн дахин зугтав; мөн тэд Моронайн их цэрэгтэй дахин тулгарав.
- 43 Эдүгээ энэ нөхцөлд леменчүүд үлэмж улайран тулалджээ; тийм ээ, леменчүүд хэзээ ч ийм агуу хүч хийгээд зоригтойгоор тулалдсан нь бүр эхлэлээс хүртэл үзэгдсэн нь үгүй болой.
- 44 Мөн тэд өөрсдийн ерөнхий ахмадууд хийгээд удирдагчид асан зорамчууд мөн амалекайчуудаар мөн тэдний ерөнхий ахмад эсвээс тэдний ерөнхий удирдагч мөн захирагч асан Зерахемнагаар зоригжуулагдав; тийм ээ, тэд луу лугаа адил тулалдаж, мөн нифайчуудаас олон нь тэдний гарт алагдав; тийм ээ, учир нь толгойн дуулгуудаас нь олныг хоёр хуваан цөм цохиж, мөн тэд цээжний хуягуудаас нь олныг нэвт цоолж, мөн тэдний олных нь гарыг тас цавчжээ; мөн тийн леменчүүд хэрцгий догшин уурандаа цохин байв.
- 45 Гэсэн хэдий ч нифайчууд зөв шалтгааны улмаас зоригжуулагдав, учир нь тэд эзэрхийллийн хийгээд эрх мэдлийн төлөө тулалдаагүй, харин гэр орон мөн эрх чөлөөнийхөө, эхнэр хийгээд хүүхдүүдийнхээ төлөө мөн байгаа бүгдийнхээ төлөө, тийм ээ, шүтэн бишрэх эрх мөн сүмийнхээ төлөө тулалдсан юм.
- 46 Мөн тэд Бурхандаа өргөх ёстой үүрэг хэмээн бодсон түүнийгээ хийж байв; учир нь Их Эзэн тэдэнд, мөн түүнчлэн тэдний эцэг өвгөдөд, тийн: Та нар эхний болон хоёр дахь өдөөн хатгалгад буруугүй байхын хэрээр, та нар дайснуудынхаа гарт эрсдэхийг тэвчихгүй байх болно хэмээн хэлсэн ажгуу.

And it came to pass that the Lamanites became frightened, because of the great destruction among them, even until they began to flee towards the river Sidon.

And they were pursued by Lehi and his men; and they were driven by Lehi into the waters of Sidon, and they crossed the waters of Sidon. And Lehi retained his armies upon the bank of the river Sidon that they should not cross.

And it came to pass that Moroni and his army met the Lamanites in the valley, on the other side of the river Sidon, and began to fall upon them and to slay them.

And the Lamanites did flee again before them, towards the land of Manti; and they were met again by the armies of Moroni.

Now in this case the Lamanites did fight exceedingly; yea, never had the Lamanites been known to fight with such exceedingly great strength and courage, no, not even from the beginning.

And they were inspired by the Zoramites and the Amalekites, who were their chief captains and leaders, and by Zerahemnah, who was their chief captain, or their chief leader and commander; yea, they did fight like dragons, and many of the Nephites were slain by their hands, yea, for they did smite in two many of their head-plates, and they did pierce many of their breast-plates, and they did smite off many of their arms; and thus the Lamanites did smite in their fierce anger.

Nevertheless, the Nephites were inspired by a better cause, for they were not fighting for monarchy nor power but they were fighting for their homes and their liberties, their wives and their children, and their all, yea, for their rites of worship and their church.

And they were doing that which they felt was the duty which they owed to their God; for the Lord had said unto them, and also unto their fathers, that: Inasmuch as ye are not guilty of the first offense, neither the second, ye shall not suffer yourselves to be slain by the hands of your enemies.

47 Мөн түүнчлэн Их Эзэн хэлсэн нь: Та нар цус урсах хүртэл ч гэсэн гэр бүлээ хамгаалах болно хэмээжээ. Тиймийн тул энэ шалтгааны учир нифайчууд өөрсдийгөө, мөн гэр бүлээ мөн газар нутгаа, эх орноо, эрхээ, мөн шашин шүтлэгээ хамгаалахаар леменчүүдтэй тулалдаж байв.

48 Мөнхүү улиран тохиох дор Моронайн эрс леменчүүдийн хэрцгий догшныг мөн уурыг нь үзээд, тэд нугдайн мөн тэднээс зугтахад ойрхон байв. Мөн Моронай тэдний зорилгыг ойлгосон учир, үгийг илгээж мөн тэдний зүрх сэтгэлийг эдгээр бодлоор— тийм ээ, газар нутаг, эрх чөлөөнийх нь, тийм ээ, дарангуйллаас тусгаар байдлын тухай бодлуудаар зоригжуулав.

49 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийг эргэн довтолж, мөн тэд нэгэн дуугаар Их Эзэн Бурхандаа хандан эрх чөлөө мөн дарангуйллаас тусгаар байдлынхаа төлөө залбиран гуйв.

50 Мөн тэд леменчүүдийн эсрэг хүчтэйгээр зогсож эхлэв; мөн тэд Их Эзэнд эрх чөлөөнийхөө төлөө залбиран гуйсан чухам тэр цагт, леменчүүд тэдний өмнө зугтаж эхлэв; мөн тэд бүр Сидоны усанд хүртэл зугтав.

51 Эдүгээ, леменчүүд тоогоор илүү олон, тийм ээ, нифайчуудын тоог хоёр нугалснаас илүү байв; гэсэн хэдий ч тэд туугдаж, үүнийхээ хэрээр тэд уг хөндийд Сидон голын эрэг дээр нэг хэсэгт нэгдэн цуглуулав.

52 Тиймийн тул Моронайн их цэрэг тэднийг бүсэлж, тийм ээ, бүр голын хоёр эргээр, учир нь болгоогтун зүүн эрэгт нь Лихайн эрчүүд байв.

53 Тиймийн тул Зерахемна Сидон голын зүүн эрэг дээрх Лихайн эрчүүдийг мөн Сидон голын баруун эрэг дээрх Моронайн их цэргийг, тэд нифайчуудаар бүслэгдсэнээ хараад, тэд айн цочирдов.

54 Эдүгээ Моронай, тэдний айдсыг хараад, өөрийн эрчүүдэд тэдний цусыг урсгахаа зогсоохыг зарлиг болов.

And again, the Lord has said that: Ye shall defend your families even unto bloodshed. Therefore for this cause were the Nephites contending with the Lamanites, to defend themselves, and their families, and their lands, their country, and their rights, and their religion.

And it came to pass that when the men of Moroni saw the fierceness and the anger of the Lamanites, they were about to shrink and flee from them. And Moroni, perceiving their intent, sent forth and inspired their hearts with these thoughts—yea, the thoughts of their lands, their liberty, yea, their freedom from bondage.

And it came to pass that they turned upon the Lamanites, and they cried with one voice unto the Lord their God, for their liberty and their freedom from bondage.

And they began to stand against the Lamanites with power; and in that selfsame hour that they cried unto the Lord for their freedom, the Lamanites began to flee before them; and they fled even to the waters of Sidon.

Now, the Lamanites were more numerous, yea, by more than double the number of the Nephites; nevertheless, they were driven insomuch that they were gathered together in one body in the valley, upon the bank by the river Sidon.

Therefore the armies of Moroni encircled them about, yea, even on both sides of the river, for behold, on the east were the men of Lehi.

Therefore when Zerahemnah saw the men of Lehi on the east of the river Sidon, and the armies of Moroni on the west of the river Sidon, that they were encircled about by the Nephites, they were struck with terror.

Now Moroni, when he saw their terror, commanded his men that they should stop shedding their blood.

## Алма 44

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэд зогсож мөн тэднээс алхам хойш ухарцгаав. Мөн Моронай Зерахемнад: Болгоогтун, Зерахемна, бид хүмүүний цусанд шунасан хүмүүс байхыг хүсдэггүй. Та нар бидний гарт байгаага мэднэ, гэсэн ч бид та нарыг алахыг хүсэхгүй байна гэж хэлэв.
- 2 Болгоогтун, бид эзэрхийллийн төлөө та нарын цусыг урсгаж болохын тулд та нарын эсрэг тулалдах гэж ирсэнгүй; бас бид хэнийг ч боолчлолын буулганд оруулахыг хүсэхгүй байна. Гэвч бидний эсрэг ирсэн та нарын чухамхүү шалтгаан нь энэ билээ; тийм ээ, та нар манай шашны учир бидэнд ууртай байна.
- 3 Гэвч эдүгээ, Их Эзэн бидэнтэй хамт гэдгийг та нар болгоогтун; мөн тэрээр та нарыг бидний гарт оруулсныг та нар болгоогтун. Мөн эдүгээ бидний шашин мөн Христэд итгэх итгэлийн маань учир энэ нь бидэнд хийгдсэн гэдгийг ойлгоосой хэмээнэ би. Мөн эдүгээ та нар бидний энэ итгэлийг устгаж чадахгүйгээ харлаа.
- 4 Эдүгээ та нар энэ бол Бурханы үнэн шашин гэдгийг харлаа; тийм ээ, бид түүнд, мөн өөрсдийн бишрэл, мөн өөрсдийн шашинд үнэнч байсан цагт, Бурхан биднийг дэмжиж, мөн хамгаалан мөн хадгалан үлдээнэ гэдгийг та нар харлаа; мөн бид зөрчилд унаж мөн сүсэг бишрэлээ үгүйсгэхгүй аваас Их Эзэн хэзээ ч биднийг устгагдахыг тэвчих нь үгүй.
- 5 Мөн эдүгээ, Зерахемна, та нарыг дийлэх хүчийг олоход бидний гарыг хүчирхэгжүүлсэн бүхнээс хүчит Бурханы нэрээр, бид өөрсдийн итгэлээр, шашин шүтлэгээрээ, мөн шүтэн бишрэх ёсоороо, мөн сүмээрээ, мөн өөрсдийн эхнэр мөн хүүхдүүддээ өгөх ёстой эрхэм нандин дэмжлэгээр, газар нутагт минь мөн улс оронд минь биднийг нэгтгэдэг эрх чөлөөгөөр; тийм ээ, мөн түүнчлэн бидний бүх аз жаргалын эх үүсвэр болох, Бурханы нандин үгийг хадгалан үлдээснээр; мөн бидэнд хамгийн эрхэм болох тэр бүгдээр би чамд зарлиглаж байна—

## Alma 44

And it came to pass that they did stop and withdrew a pace from them. And Moroni said unto Zerahemnah: Behold, Zerahemnah, that we do not desire to be men of blood. Ye know that ye are in our hands, yet we do not desire to slay you.

Behold, we have not come out to battle against you that we might shed your blood for power; neither do we desire to bring any one to the yoke of bondage. But this is the very cause for which ye have come against us; yea, and ye are angry with us because of our religion.

But now, ye behold that the Lord is with us; and ye behold that he has delivered you into our hands. And now I would that ye should understand that this is done unto us because of our religion and our faith in Christ. And now ye see that ye cannot destroy this our faith.

Now ye see that this is the true faith of God; yea, ye see that God will support, and keep, and preserve us, so long as we are faithful unto him, and unto our faith, and our religion; and never will the Lord suffer that we shall be destroyed except we should fall into transgression and deny our faith.

And now, Zerahemnah, I command you, in the name of that all-powerful God, who has strengthened our arms that we have gained power over you, by our faith, by our religion, and by our rites of worship, and by our church, and by the sacred support which we owe to our wives and our children, by that liberty which binds us to our lands and our country; yea, and also by the maintenance of the sacred word of God, to which we owe all our happiness; and by all that is most dear unto us—



6 Тийм ээ, мөн энэ бол бүгд бус; амь насныхаа төлөө та нарт байгаа бүх хүслүүдээр тань, дайны зэр зэвсгээ бидэнд өгөхийг би та нарт зарлиглана, мөн бид та нарын цусыг эрэлхийлэхгүй, харин та нар замаараа явж мөн бидний эсрэг дайтахаар дахин ирэхгүй аваас амийг тань бид хэлтрүүлэх болно.

7 Мөн эдүгээ, хэрэв та нар ийнхүү үйлдэхгүй аваас, болгоогтун, та нар бидний гарт байна, мөн та нарыг дайрахыг, мөн та нар бүрмөсөн үгүй болж болохын тул, биед чинь үхлийн шарх учруулахыг би өөрийн хүмүүст тушаах болно; мөн тэгээд бид энэ хүмүүсийн дээр хэн нь хүчтэй байхыг харах болно; тийм ээ, хэн боолчлолд авчрагдахыг бид үзэх болно.

8 Мөн эдүгээ улиран тохиох дор Зерахемна эдгээр хэлснийг нь сонсоод тэрээр урагшилж мөн сэлэм мөн илдээ, бас нумаа Моронайн гарт өгч, мөн түүнд хэлэв: Болгоогтун, бидний дайны зэр зэвсэг энэ байна; бид тэдгээрийг та нарт өгье, гэвч бид мөн түүнчлэн бидний хүүхдүүд зөрчинө гэдгийг мэдсээр байж та нарт тангараглахыг тэвчихгүй; харин дайны зэр зэвсгийг маань ав, мөн биднийг аглаг буйд тийш зайлан одохыг зөвшөөр; үгүй бол бид илдээ авч үлдээд, мөн мөхөх эсвэл ялан дийлэх болно.

9 Болгоогтун, бид танай сүсэг бишрэлийнхэн бус; биднийг та нарын гарт оруулсан нь Бурхан гэдэгт бид үл итгэнэ; харин та нарыг бидний илднүүдээс хамгаалсан нь та нарын башир арга гэдэгт итгэнэ. Болгоогтун, та нарыг хамгаалсан нь та нарын цээжний хуяг мөн бамбайнууд чинь юм.

10 Мөн эдүгээ Зерахемна эдгээр үгийг ярьснаа төгсгөл болгоход, Моронай өөрт хүлээн авсан илд мөн дайны зэвсгүүдийг нь Зерахемнад буцааж өгөөд, хэлсэн нь: Болгоогтун, бид зөрчилдөөнийг төгсгөнө.

11 Эдүгээ би ярьсан үгээ буцааж чадахгүй, тиймийн тул Их Эзэн амьдын адил, та нар бидний эсрэг дайтахаар эргэж ирэхгүй гэсэн тангарагтайгаар явахгүй бол та нар явахгүй. Эдүгээ та нар бидний гарт байгаа учир цусыг чинь газарт асгах болно, эсвээс та нар миний санал болгосон нөхцлүүдэд захирагдах болно.

Yea, and this is not all; I command you by all the desires which ye have for life, that ye deliver up your weapons of war unto us, and we will seek not your blood, but we will spare your lives, if ye will go your way and come not again to war against us.

And now, if ye do not this, behold, ye are in our hands, and I will command my men that they shall fall upon you, and inflict the wounds of death in your bodies, that ye may become extinct; and then we will see who shall have power over this people; yea, we will see who shall be brought into bondage.

And now it came to pass that when Zerahemnah had heard these sayings he came forth and delivered up his sword and his cimeter, and his bow into the hands of Moroni, and said unto him: Behold, here are our weapons of war; we will deliver them up unto you, but we will not suffer ourselves to take an oath unto you, which we know that we shall break, and also our children; but take our weapons of war, and suffer that we may depart into the wilderness; otherwise we will retain our swords, and we will perish or conquer.

Behold, we are not of your faith; we do not believe that it is God that has delivered us into your hands; but we believe that it is your cunning that has preserved you from our swords. Behold, it is your breastplates and your shields that have preserved you.

And now when Zerahemnah had made an end of speaking these words, Moroni returned the sword and the weapons of war, which he had received, unto Zerahemnah, saying: Behold, we will end the conflict.

Now I cannot recall the words which I have spoken, therefore as the Lord liveth, ye shall not depart except ye depart with an oath that ye will not return again against us to war. Now as ye are in our hands we will spill your blood upon the ground, or ye shall submit to the conditions which I have proposed.

12 Мөн эдүгээ Моронай эдгээр үгийг хэлсний дараа, Зерахемна илдээ буцаан авч, мөн тэрээр Моронайд уурлаж, мөн Моронайг алж болохын тулд урагш ухасхийв; гэвч түүнийг илдээ өргөмөгц, болгоогтун Моронайн цэргүүдээс нэг нь илдийг нь газар унатал цохиж, мөн энэ нь бариулаараа хугарав; мөн түүнчлэн тэрээр Зерахемнаг цохиж ингэснээр түүний хуйхыг тас цавчсанд мөн энэ нь хөсөр унав. Мөн Зерахемна тэдний өмнөөс ухран цэргүүдийнхээ дунд хүрэв.

13 Мөнхүү улиран тохиох дор хажууд нь зогсож байсан, Зерахемнагийн хуйхыг тас цохисон тэр цэрэг, мөнөө хуйхыг үснээс нь барьж газраас аваад, мөн илднийхээ үзүүр дээр тавьж, мөн тэдний зүг сунгаж, чанга дуугаар тэдэнд хэлсэн нь:

14 Та нар зэр зэвсгээ өгч мөн энхийн гэрээтэйгээр явахгүй бол бүр удирдагчийн чинь хуйх болох, энэ хуйх газарт унасанчлан, та нар ч газарт унах болно.

15 Эдүгээ тэд эдгээр үгийг сонсож мөн илдэн дээрх хуйхыг хараад айж балмагдсан нь олон байв; мөн олон нь урагшилж мөн дайны зэвсгүүдээ Моронайн хөлд хаяж, мөн энхийн гэрээнд оров. Мөн гэрээнд орсон болгонд аглаг буйд тийш одохыг зөвшөөрөв.

16 Эдүгээ улиран тохиох дор Зерахемна үлэмж ихээр хилэгнэн, мөн тэрээр цэргүүдийнхээ үлдсэнийг нь нифайчуудын эсрэг илүү хүчтэйгээр тэмцэлдүүлэхээр уурлуулахад өдөөн хатгав.

17 Мөн эдүгээ Моронай леменчүүдийн зөрүүдийн учир уурлав; тиймийн тул тэрээр тэдний зүг довтолж мөн тэднийг алахыг өөрийн хүмүүст зарлиглав. Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг алж эхлэв; тийм ээ, мөн леменчүүд илдээрээ бас чадлаараа тэмцэлдэв.

18 Гэвч болгоогтун тэдний нүцгэн арьс мөн тэдний нүцгэн толгой нифайчуудын хурц илдэнд эрсэдсэн байв; тийм ээ болгоогтун тэд цоо хатгагдаж мөн цавчигдав, тийм ээ, мөн нифайчуудын илдний өмнө үлэмж хурдан унаж байв; мөн бүр Моронайн цэргийн бошиглон хэлсэнчлэн тэд хиарч эхлэв.

And now when Moroni had said these words, Zerahemnah retained his sword, and he was angry with Moroni, and he rushed forward that he might slay Moroni; but as he raised his sword, behold, one of Moroni's soldiers smote it even to the earth, and it broke by the hilt; and he also smote Zerahemnah that he took off his scalp and it fell to the earth. And Zerahemnah withdrew from before them into the midst of his soldiers.

And it came to pass that the soldier who stood by, who smote off the scalp of Zerahemnah, took up the scalp from off the ground by the hair, and laid it upon the point of his sword, and stretched it forth unto them, saying unto them with a loud voice:

Even as this scalp has fallen to the earth, which is the scalp of your chief, so shall ye fall to the earth except ye will deliver up your weapons of war and depart with a covenant of peace.

Now there were many, when they heard these words and saw the scalp which was upon the sword, that were struck with fear; and many came forth and threw down their weapons of war at the feet of Moroni, and entered into a covenant of peace. And as many as entered into a covenant they suffered to depart into the wilderness.

Now it came to pass that Zerahemnah was exceedingly wroth, and he did stir up the remainder of his soldiers to anger, to contend more powerfully against the Nephites.

And now Moroni was angry, because of the stubbornness of the Lamanites; therefore he commanded his people that they should fall upon them and slay them. And it came to pass that they began to slay them; yea, and the Lamanites did contend with their swords and their might.

But behold, their naked skins and their bare heads were exposed to the sharp swords of the Nephites; yea, behold they were pierced and smitten, yea, and did fall exceedingly fast before the swords of the Nephites; and they began to be swept down, even as the soldier of Moroni had prophesied.

19 Эдүгээ Зерахемна, тэрээр тэд бараг бүгд устгагдах гэж байгаагаа хараад, Моронайд, хэрэв тэд үлдсэн тэдний амийг хэлтрүүлэх аваас, тэр мөн түүнчлэн түүний хүмүүс хэзээ ч тэдний эсрэг дайтахаар ирэхгүй хэмээн тэдэнтэй гэрээ хийхийг тэнхээгээрээ хашгирч амлав.

20 Мөнхүү улиран тохиох дор Моронай хүмүүсийн дундах аллагыг болиулахаар болгов. Мөн тэрээр леменчүүдээс дайны зэвсгийг нь авчээ; мөн тэд түүнтэй энхийн гэрээ хийснийхээ дараа аглаг буйд тийш одох нь зөвшөөрөгдөв.

21 Эдүгээ үхэгсдийн тоо нь тооны ихийн улмаас тоологдсонгүй; тийм ээ, нифайчуудаас мөн леменчүүдээс аль алинаас нь үхэгсдийн тоо үлэмж их байв.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд үхэгсдээ Сидон голын усанд хаяж, мөн тэдгээр нь урсаж тэнгисийн гүнд булшлагдав.

23 Мөн нифайчуудын, өөрөөр хэлбэл Моронайн их цэрэг, эргэж мөн өөрсдийн гэр орон мөн нутагтаа ирэв.

24 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван найм дахь он тийн төгсөв. Мөн Нифайн ялтсууд дээр бичигдсэн, Алмагийн цэдэгийн төгсөв.

Now Zerahemnah, when he saw that they were all about to be destroyed, cried mightily unto Moroni, promising that he would covenant and also his people with them, if they would spare the remainder of their lives, that they never would come to war again against them.

And it came to pass that Moroni caused that the work of death should cease again among the people. And he took the weapons of war from the Lamanites; and after they had entered into a covenant with him of peace they were suffered to depart into the wilderness.

Now the number of their dead was not numbered because of the greatness of the number; yea, the number of their dead was exceedingly great, both on the Nephites and on the Lamanites.

And it came to pass that they did cast their dead into the waters of Sidon, and they have gone forth and are buried in the depths of the sea.

And the armies of the Nephites, or of Moroni, returned and came to their houses and their lands.

And thus ended the eighteenth year of the reign of the judges over the people of Nephi. And thus ended the record of Alma, which was written upon the plates of Nephi.

*Хиламаны өдрүүд дэх Нифайн хүмүүсийн мөн тэдний дайнууд мөн зөрөлдөөнүүдийн шастир, тэрээр өөрийн өдрүүдэд хөтөлсөн тэрхүү, Хиламаны цэдгийн дагуу оршвой.*

## Алма 45

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүс үлэмж баясав, учир нь Их Эзэн тэднийг дайнуудынх нь гараас дахин чөлөөлжээ; тиймийн тул тэд Их Эзэн Бурхандаа талархал мэдүүлэв; тийм ээ, мөн тэд ихэд мацаг барьж мөн ихэд залбирч, мөн үлэмж агуу баяраар тэд Бурханаа шүтэн бишрэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван ес дэх онд, Алма өөрийн хүү Хиламанд ирж мөн түүнд хэлэв: Хадгалагдсан цэдгүүдийн талаар чамд миний ярьсан тэдгээр үгсэд чи итгэдэг үү
- 3 Мөн Хиламан түүнд хэлэв: Тийм ээ, би итгэдэг.
- 4 Мөн Алма үүнчлэн хэлэв: Ирэх Есүс Христэд чи итгэдэг үү
- 5 Мөн тэрээр хэлсэн нь: Тийм ээ, би таны ярьсан бүх үгэнд итгэдэг.
- 6 Мөн Алма түүнд үүнчлэн хэлэв: Чи миний зарлигуудыг дагах уу
- 7 Мөн тэрээр хэлэв: Тийм ээ, би таны зарлигуудыг бүх сэтгэл зүрхээрээ дагах болно.
- 8 Тэгэхэд нь Алма түүнд хэлэв: Адислагдсан болой чи; мөн Их Эзэн чамайг энэ нутагт дэгжээх болно.
- 9 Гэвч болгоогтун, чамд бошиглох зарим зүйл надад байна; гэвч чамд миний бошиглохыг чи мэдүүлэхгүй; тийм ээ, миний чамд бошиглох нь мэдүүлэгдэх ёсгүй, бүр бошиглол нь гүйцэлдэх хүртэл; тиймийн тул миний хэлэх үгсийг бичигтүн.
- 10 Мөн үгс нь эдгээр буюу: Болгоогтун, Есүс Христ өөрийгөө тэдэнд үзүүлэх тэр цагаас дөрвөн зуун жилийн хойно чухам энэ хүмүүс, нифайчууд, итгэлгүйдээ бууран доройтох болно гэдгийг би өөрт буй илчлэлтийн суу билгийн дагуу ойлгон ухаарч байна.
- 11 Тийм ээ, мөн тэгээд тэд дайнууд мөн тахлуудыг, тийм ээ, өлсгөлөнгүүд мөн цус урсалтыг, бүр Нифайн хүмүүс бүрмөсөн үгүй болтол үзэх болно—

*The account of the people of Nephi, and their wars and dissensions, in the days of Helaman, according to the record of Helaman, which he kept in his days.*

## Alma 45

Behold, now it came to pass that the people of Nephi were exceedingly rejoiced, because the Lord had again delivered them out of the hands of their enemies; therefore they gave thanks unto the Lord their God; yea, and they did fast much and pray much, and they did worship God with exceedingly great joy.

And it came to pass in the nineteenth year of the reign of the judges over the people of Nephi, that Alma came unto his son Helaman and said unto him: Believest thou the words which I spake unto thee concerning those records which have been kept?

And Helaman said unto him: Yea, I believe.

And Alma said again: Believest thou in Jesus Christ, who shall come?

And he said: Yea, I believe all the words which thou hast spoken.

And Alma said unto him again: Will ye keep my commandments?

And he said: Yea, I will keep thy commandments with all my heart.

Then Alma said unto him: Blessed art thou; and the Lord shall prosper thee in this land.

But behold, I have somewhat to prophesy unto thee; but what I prophesy unto thee ye shall not make known; yea, what I prophesy unto thee shall not be made known, even until the prophecy is fulfilled; therefore write the words which I shall say.

And these are the words: Behold, I perceive that this very people, the Nephites, according to the spirit of revelation which is in me, in four hundred years from the time that Jesus Christ shall manifest himself unto them, shall dwindle in unbelief.

Yea, and then shall they see wars and pestilences, yea, famines and bloodshed, even until the people of Nephi shall become extinct—

- 12 Тийм ээ, мөн тэд итгэлгүйдээ бууран доройтож мөн харанхуйн мөн шунаг тачаангуйн ажилд мөн бүх төрлийн алдаст унах учир энэ болой; тийм ээ, би чамд хэлнэ, тэд ийм агуу гэрэл мөн мэдлэгийн эсрэг нүгэл үйлдэх учир, тийм ээ, би чамд хэлнэ, тэр өдрөөс, энэхүү агуу алдас ирэхээс өмнө дөрөв дэх үеийнхэн бүгд улиран одоогүй байх болно.
- 13 Мөн тэр агуу өдрийг ирэхэд, болгоогтун одоо тоологдсон тэд өөрөөр хэлбэл эдүгээ Нифайн хүмүүсийн дунд тоологдсон тэдний үр удам, цаашид Нифайн хүмүүсийн дунд тоологдохгүй тэр цаг тун удахгүй ирэх болно.
- 14 Харин үлдэх мөн агуу мөн аймшигт өдөр устгадаагүй хэн боловч, леменчүүдийн дунд тоологдож мөн тэдэнтэй адил болох болно, Их Эзэний шавь нар гэж нэрлэгдэх цөөн хэдээс бусад нь бүгд; мөн тэднийг леменчүүд бүрмөсөн үгүй болох хүртэл нь мөрдөн мөшгөх болно. Мөн эдүгээ, алдсын учир, энэ бошиглол гүйцэлдэх болно.
- 15 Мөн эдүгээ улиран тохиох дор Алма эдгээр зүйлийг Хиламанд хэлсний дараа тэрээр түүнийг, мөн түүнчлэн өөрийн бусад хөвгүүдийг адислав; мөн түүнчлэн тэр газар дэлхийг зөв шударгыг үйлдэгсдийн төлөө адислав.
- 16 Мөн тэрээр хэлсэн нь: Их Эзэн Бурхан ийн хэлэв—Ёс бусыг үйлдэх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүс болгонд, тэд боловсорч гүйцэх үед, уг нутаг, тийм ээ, энэ нутаг, устгалдаа хүртэл зүхэгдэх болно; мөн миний хэлсэнчлэн энэ нь ийм байх болно; учир нь энэ бол уг нутаг дээрх Бурханы зүхэл мөн адислал юм, учир нь нүглийг Их Эзэн хамгийн бага хэмжээгээр байлаа ч гэсэн хүлээн зөвшөөрч чаддаггүй.
- 17 Мөн эдүгээ Алма эдгээр үгийг хэлээд тэрээр сүмийг, тийм ээ, тэр цагаас хойш сүсэг бишрэлдээ тууштай зогсох тэд бүгдийг адислав.
- 18 Мөн Алма үүнийг хийгээд тэрээр Зерахемлагийн нутгаас гарч, Мелекийн нутагт одох мэтээр явсан бөлгөө. Мөнхүү улиран тохиох дор тэрээр хэзээ ч дахин сонсогдсонгүй; түүний үхэл эсвээс оршуулгын тухай бид мэдэх нь үгүй.

Yea, and this because they shall dwindle in unbelief and fall into the works of darkness, and lasciviousness, and all manner of iniquities; yea, I say unto you, that because they shall sin against so great light and knowledge, yea, I say unto you, that from that day, even the fourth generation shall not all pass away before this great iniquity shall come.

And when that great day cometh, behold, the time very soon cometh that those who are now, or the seed of those who are now numbered among the people of Nephi, shall no more be numbered among the people of Nephi.

But whosoever remaineth, and is not destroyed in that great and dreadful day, shall be numbered among the Lamanites, and shall become like unto them, all, save it be a few who shall be called the disciples of the Lord; and them shall the Lamanites pursue even until they shall become extinct. And now, because of iniquity, this prophecy shall be fulfilled.

And now it came to pass that after Alma had said these things to Helaman, he blessed him, and also his other sons; and he also blessed the earth for the righteous' sake.

And he said: Thus saith the Lord God—Cursed shall be the land, yea, this land, unto every nation, kindred, tongue, and people, unto destruction, which do wickedly, when they are fully ripe; and as I have said so shall it be; for this is the cursing and the blessing of God upon the land, for the Lord cannot look upon sin with the least degree of allowance.

And now, when Alma had said these words he blessed the church, yea, all those who should stand fast in the faith from that time henceforth.

And when Alma had done this he departed out of the land of Zarahemla, as if to go into the land of Melek. And it came to pass that he was never heard of more; as to his death or burial we know not of.

- 19 Болгоогтун, бид үүнийг, тэрээр зөв шударга хүн байсныг мэднэ; мөн бүр Мосе лугаа адил, тэрээр Сүнсээр дээш аваачигдсан, өөрөөр хэлбэл Их Эзэний мутраар оршуулагдсан гэдэг яриа сүмд тархжээ. Гэвч болгоогтун, Их Эзэн Мосег өөртөө авсан хэмээн судрууд өгүүлдэг; мөн түүнчлэн Алмаг сүнсээр өөртөө хүлээн авсан хэмээн бид боддог; тиймийн тул, энэ шалтгааны учир түүний үхэл мөн оршуулгын талаар бид юу ч мэддэггүй.
- 20 Мөн эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван ес дэх оны эхэнд, Хиламан тэдэнд үгийг тунхаглахаар хүмүүсийн дунд одов.
- 21 Учир нь болгоогтун, леменчүүдтэй хийсэн тэдний дайнууд мөн хүмүүсийн дунд байсан олон жижиг зөрөлдөөнүүд хийгээд үймээнүүдийн учир тэдний дунд Бурханы үг тунхаглагдах нь, тийм ээ, мөн сүм даяар зохицуулалт хийгдэх нь зайлшгүй болов.
- 22 Тиймийн тул, Хиламан болон түүний ах дүүс бүх нутагт сүмийг дахин тохинуулахаар, тийм ээ, Нифайн хүмүүсээр эзэмшигдсэн тэр бүх нутаг даяар хот болгонд одов. Мөнхүү улиран тохиох дор тэд бүх сүмүүдийн дээрх санваартнууд болон багш нарыг бүх нутаг даяар томилов.
- 23 Мөн эдүгээ улиран тохиох дор Хиламан болон түүний ах дүүс сүмүүдийн дээрх санваартнууд хийгээд багш нарыг томилсны дараа тэдний дунд зөрөлдөөн гарч, мөн тэдний Хиламан болон түүний ах дүүсийн үгсэд анхаарал тавихгүй байв;
- 24 Харин өөрсдийн агуу баялгуудын улмаас сэтгэлдээ хөөрсний учир тэд бардам болжээ; тиймийн тул өөрсдийн нүдэнд тэд баян болж, мөн Бурханы өмнө зөв шударгаар алхуулах тэдний үгсэд анхаарал тавихгүй байлаа.

Behold, this we know, that he was a righteous man; and the saying went abroad in the church that he was taken up by the Spirit, or buried by the hand of the Lord, even as Moses. But behold, the scriptures saith the Lord took Moses unto himself; and we suppose that he has also received Alma in the spirit, unto himself; therefore, for this cause we know nothing concerning his death and burial.

And now it came to pass in the commencement of the nineteenth year of the reign of the judges over the people of Nephi, that Helaman went forth among the people to declare the word unto them.

For behold, because of their wars with the Lamanites and the many little dissensions and disturbances which had been among the people, it became expedient that the word of God should be declared among them, yea, and that a regulation should be made throughout the church.

Therefore, Helaman and his brethren went forth to establish the church again in all the land, yea, in every city throughout all the land which was possessed by the people of Nephi. And it came to pass that they did appoint priests and teachers throughout all the land, over all the churches.

And now it came to pass that after Helaman and his brethren had appointed priests and teachers over the churches that there arose a dissension among them, and they would not give heed to the words of Helaman and his brethren;

But they grew proud, being lifted up in their hearts, because of their exceedingly great riches; therefore they grew rich in their own eyes, and would not give heed to their words, to walk uprightly before God.

## Алма 46

- 1 Мөнхүү улиран тохиох дор Хиламан мөн түүний ах дүүсийн үгийг дуулаагүй болгон нь бүгд ах дүүсийнхээ эсрэг нэгдэн цугларав.
- 2 Мөн эдүгээ болгоогтун, тэд үлэмж хилэгнэж, үүнийхээ хэрээр тэднийг хөнөөхөөр шийдсэн байв.
- 3 Эдүгээ ах дүүсийнхээ эсрэг хилэгнэсэн тэдний удирдагч нь том биетэй мөн хүчирхэг эр байв; мөн түүний нэрийг Амаликая гэдэг байв.
- 4 Мөн Амаликая хаан болох хүсэлтэй байв; мөн хилэгнэсэн тэдгээр хүмүүс түүнийг хаанаа байгаасай хэмээн хүсэв; мөн тэдний ихэнх хэсэг нь нутгийн бага эрх мэдэлтэй шүүгчид байв, мөн тэд хүчийг эрэлхийлж байв.
- 5 Мөн хэрэв тэд түүнийг дэмжиж мөн түүнийг хаанаа болговол тэр тэднийг хүмүүсийн дээрх захирагч болгоно хэмээх Амаликаягийн зусардалтанд тэд удирдагдсан байв.
- 6 Тэд сүмийн дээрх дээд санваартнууд байсны учир, Хиламан мөн түүний ах дүүсийн номлолыг үл ойшоон, тийм ээ, сүмийн дээрх тэдний агуу халамжийг үл ойшоон, тэд Амаликаягаар тийн тэрсэлдээнд удирдагдсан болой.
- 7 Мөн Амаликаягийн зусар үгсэд итгэсэн нь сүмийн дотор олон байв, тиймийн тул тэд бүр сүмээс ч тэрслэв; мөн леменчүүдийг давсан тэдний тэрхүү агуу ялалт, мөн Их Эзэний мутраар чөлөөлөгдсөний учир тэдэнд тэр агуу баясал байсан хэдий ч, Нифайн хүмүүсийн байдал ийн үлэмж найдваргүй мөн аюултай байв.
- 8 Хүмүүний үрс Их Эзэн Бурханаа хичнээн хурдан мартдагийг, тийм ээ, алдсыг үйлдэхэд, мөн хилэнцэт нэгнээр удирдагдахдаа хичнээн хурдныг бид ийн харлаа.
- 9 Тийм ээ, мөн түүнчлэн нэгэн ихэд ёс бус хүн, хүмүүний үрсийн дунд ямар агуу ёс бусыг үйлдүүлж чаддагийг бид харлаа.

## Alma 46

And it came to pass that as many as would not hearken to the words of Helaman and his brethren were gathered together against their brethren.

And now behold, they were exceedingly wroth, inso-much that they were determined to slay them.

Now the leader of those who were wroth against their brethren was a large and a strong man; and his name was Amalickiah.

And Amalickiah was desirous to be a king; and those people who were wroth were also desirous that he should be their king; and they were the greater part of them the lower judges of the land, and they were seeking for power.

And they had been led by the flatteries of Amalickiah, that if they would support him and establish him to be their king that he would make them rulers over the people.

Thus they were led away by Amalickiah to dissensions, notwithstanding the preaching of Helaman and his brethren, yea, notwithstanding their exceedingly great care over the church, for they were high priests over the church.

And there were many in the church who believed in the flattering words of Amalickiah, therefore they dissented even from the church; and thus were the affairs of the people of Nephi exceedingly precarious and dangerous, notwithstanding their great victory which they had had over the Lamanites, and their great rejoicings which they had had because of their deliverance by the hand of the Lord.

Thus we see how quick the children of men do forget the Lord their God, yea, how quick to do iniquity, and to be led away by the evil one.

Yea, and we also see the great wickedness one very wicked man can cause to take place among the children of men.

10 Тийм ээ, Амаликаяг, тэрээр башир аргатай мөн олон зусар үгтэй хүн байсан учир, олон хүмүүний зүрх сэтгэлийг ёс бусыг хийхэд; тийм ээ, мөн Бурханы сүмийг устгахыг, мөн Бурханы тэдэнд соёрхсон, өөрөөр хэлбэл зөв шударгыг үйлдэгсдийн төлөө бүх нутгийн гадаргуу дээр адислал болгон Бурханы илгээсэн тэрхүү эрх чөлөөний үндэс суурийг устгахыг эрэлхийлэхэд тэр удирдсаныг бид харлаа.

11 Мөн эдүгээ улиран тохиох дор нифайчуудын их цэргийн ерөнхий захирагч, Моронай эдгээр тэрслэлүүдийг сонсоод, тэрээр Амаликаяд ууртай байв.

12 Мөнхүү улиран тохиох дор тэр нөмрөгөө урж; мөн үүнийхээ нэг хэсгийг нь авч, мөн үүн дээрээ —Бурханы минь, бидний шашин шүтлэгийн, мөн эрх чөлөөний, мөн бидний энх амгалангийн, эхнэр, мөн хүүхдийн минь тухай санамж болгоё—хэмээн бичиж, мөн тэрээр үүнийг савааны үзүүрт тогтоов.

13 Мөн тэрээр дуулга, мөн цээжний хуяг, мөн бамбай халхавчнуудаа зүүгээд, мөн хуягаа хэвлийн тус газраа агсав; мөн үзүүрт нь түүний урагдсан нөмрөг байлаа, (мөн тэр үүнийг эрх чөлөөний туг гэж нэрлэжээ) тэр савааг аваад мөн тэрээр газарт бөхийн сууж, мөн ах дүүсийнхээ дээр эрх чөлөөний адислалууд байгаасай хэмээн Бурхандаа хүчтэйгээр залбирав, Христийнх хэмээгдэх хэсэг уг нутгийг эзэмшихээр үлдсэн цагт буюу—

14 Учир нь Бурханы сүмд харьяалагдсан, Христийн жинхэнэ итгэгчид бүгдээрээ сүмд харьяалагдаагүй тэднээр тийн нэрлэгдсэн байв.

15 Мөн сүмд харьяалагдсан тэд итгэлтэй байв; тийм ээ, Христэд жинхэнэ итгэгчид болох тэд, ирэх тэрхүү Христэд итгэх итгэлийнхээ учир бүгд, Христийн нэрийг эсвээс нэрлэгдсэнээрээ Христийнх гэгдэхийг өөрсдийн дээр дуртайяа хүлээн авчээ.

16 Мөн тиймийн тул, энэ үед, Христийнхний хөдөлгөөн мөн уг нутгийн эрх чөлөө тааллыг олж болохын төлөө Моронай залбирав.

Yea, we see that Amalickiah, because he was a man of cunning device and a man of many flattering words, that he led away the hearts of many people to do wickedly; yea, and to seek to destroy the church of God, and to destroy the foundation of liberty which God had granted unto them, or which blessing God had sent upon the face of the land for the righteous' sake.

And now it came to pass that when Moroni, who was the chief commander of the armies of the Nephites, had heard of these dissensions, he was angry with Amalickiah.

And it came to pass that he rent his coat; and he took a piece thereof, and wrote upon it—In memory of our God, our religion, and freedom, and our peace, our wives, and our children—and he fastened it upon the end of a pole.

And he fastened on his head-plate, and his breast-plate, and his shields, and girded on his armor about his loins; and he took the pole, which had on the end thereof his rent coat, (and he called it the title of liberty) and he bowed himself to the earth, and he prayed mightily unto his God for the blessings of liberty to rest upon his brethren, so long as there should a band of Christians remain to possess the land—

For thus were all the true believers of Christ, who belonged to the church of God, called by those who did not belong to the church.

And those who did belong to the church were faithful; yea, all those who were true believers in Christ took upon them, gladly, the name of Christ, or Christians as they were called, because of their belief in Christ who should come.

And therefore, at this time, Moroni prayed that the cause of the Christians, and the freedom of the land might be favored.



- 17 Мөнхүү улиран тохиох дор тэрээр өөрийн сэтгэлийг Бурханд юулсний дараа, тэр Эзгүйрлийн нутгаас өмнөд дэх бүх нутгийг, тийм ээ, мөн дүгнэж хэлэхэд, бүх нутгийг умард ба өмнөдөд аль алинд нь байх—сонгомол нутаг, мөн эрх чөлөөний нутаг хэмээн нэрлэв.
- 18 Мөн тэрээр хэлэв: Бид Христийн нэрийг өөрсдийн дээр авсан учир гадуурхагдсан биднийг доор дэвслэгдэхийг мөн устгагдахыг, бид үүнийг өөрсдийнхөө дээр зөрчлүүдээрээ авчрах хүртэл Бурхан тэвчихгүй нь лавтай.
- 19 Мөн Моронай эдгээр үгсийг хэлээд, тэр хүмүүсийн дунд явж, нөгөөх урагдсан хэсэг дээрх өөрийнх нь бичсэнийг бүгд харж болохын тулд, өмсгөлийнхөө урагдсан хэсгээр агаарт даллан, мөн чанга дуугаар хашгирч, хэлсэн нь:
- 20 Болгоогтун, уг нутагт энэ тугийг хадгалахаар сонгосон хэн боловч, тэд Их Эзэний хүчинд нааш ирж, мөн Их Эзэн Бурхан тэднийг адисалж болохын тулд эрхээ, мөн шашин шүтлэгээ хадгалах болно гэсэн гэрээнд нэгдэгтүн.
- 21 Мөнхүү улиран тохиох дор Моронай эдгээр үгийг тунхаглахад, болгоогтун, уг хүмүүс хуягаа хэвлийн тус газраа бүслээд, тэд Их Эзэн Бурханаа орхихгүй эсвээс өөр үгээр хэлбэл, хэрэв тэд Бурханы зарлигуудыг зөрчих, эсвээс зөрчилд унаж, мөн Христийн нэрийг өөрсдийн дээр авахаас ичих аваас, тэд хувцсаа урж тасдсан шиг Их Эзэн тэднийг урвал зохино гэсний тэмдэг буюу гэрээ болгон өмсгөлүүдээ урж гүйлдэн ирцгээв.
- 22 Эдүгээ энэ нь тэдний хийсэн гэрээ байв. Мөн тэд өмсгөлүүдээ Моронайн хөлд хаяж, хэлсэн нь: Хэрэв бид зөрчилд унах аваас, уг нутгийн умард хэсэгт байсан ах дүүсийнхээ адил устгагдах болно хэмээн бид Бурхантайгаа гэрээлэв; тийм ээ, бүр бид өмсгөлүүдээ хөл доор дэвслэгдсэн байхаар таны хөлд хаясны адилаар, хэрэв бид зөрчилд унах аваас тэр биднийг дайснуудын минь хөлд хаяж болно.

And it came to pass that when he had poured out his soul to God, he named all the land which was south of the land Desolation, yea, and in fine, all the land, both on the north and on the south—A chosen land, and the land of liberty.

And he said: Surely God shall not suffer that we, who are despised because we take upon us the name of Christ, shall be trodden down and destroyed, until we bring it upon us by our own transgressions.

And when Moroni had said these words, he went forth among the people, waving the rent part of his garment in the air, that all might see the writing which he had written upon the rent part, and crying with a loud voice, saying:

Behold, whosoever will maintain this title upon the land, let them come forth in the strength of the Lord, and enter into a covenant that they will maintain their rights, and their religion, that the Lord God may bless them.

And it came to pass that when Moroni had proclaimed these words, behold, the people came running together with their armor girded about their loins, rending their garments in token, or as a covenant, that they would not forsake the Lord their God; or, in other words, if they should transgress the commandments of God, or fall into transgression, and be ashamed to take upon them the name of Christ, the Lord should rend them even as they had rent their garments.

Now this was the covenant which they made, and they cast their garments at the feet of Moroni, saying: We covenant with our God, that we shall be destroyed, even as our brethren in the land northward, if we shall fall into transgression; yea, he may cast us at the feet of our enemies, even as we have cast our garments at thy feet to be trodden under foot, if we shall fall into transgression.

23 Моронай тэдэнд хэлэв: Болгоогтун, бид Иаковын үр удмын үлдэгдэл билээ; тийм ээ, түүний дээл ах на- раар нь олон хэсэг тасчуулсан Иосефын үр удмын үл- дэгдэл билээ бид; тийм ээ, мөн эдүгээ болгоогтун, Бурханы зарлигуудыг дагахаа санацгаая, эс бөгөөс бидний өмсгөлүүд ах дүүсээр маань тасчигдан, мөн бид гянданд хаягдан, эсвээс худалдагдаж, эсвээс алаг- дах болно.

24 Тийм ээ, Иосефын үлдэгдлийн хувьд эрх чөлөөгөө хадгалан хамгаалцгаая, тийм ээ, Иаков үхлийнхээ өмнө хэлсэн үгийг санацгаая, учир нь болгоогтун, тэрээр Иосефын дээлний үлдэгдлийн нэг хэсэг нь хад- галагдаж мөн үжирч муудаагүйг харсан бөлгөө. Мөн тэр хэлсэн нь—Миний хүүгийн хувцасны энэ үлдэг- дэл хадгалагдан үлдсэний адил, тэрчлэн хүүгийн минь үр удмын нэгэн үлдэгдэл Бурханы мутраар хад- галагдан үлдсэн байжээ, мөн түүнд өөрт нь хүлээн авагдах болно, Иосефын үр удмын бусад үлдэгдэл яг түүний өмсгөлийн үлдэгдэл мэт мөхөж байхад буюу.

25 Эдүгээ болгоогтун, энэ нь бодгальд минь харуус- лыг өгдөг; гэсэн хэдий ч, бодгаль минь хүүдээ баяс- даг, Бурханд авагдах түүний үр удмын нэг хэсгийн учир бөлгөө.

26 Эдүгээ болгоогтун, энэ бол Иаковын үг яриа бай- жээ.

27 Мөн эдүгээ түүний өмсгөл лугаа адил мөхөх Иосефын үр удмын үлдэгдэл нь, биднээс тэрсэлсэн тэд байхыг хэн мэдэх билээ? Тийм ээ, мөн хэрэв бид Христэд итгэх итгэлдээ гуйвшгүйгээр зогсохгүй аваас бүр энэ нь бид өөрсдөө байх болно.

28 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай эдгээр үг- сийг хэлээд, тэрээр урагш алхаж, мөн түүнчлэн нут- гийн тэрсэлдээн байсан тэр бүх хэсгүүдэд үг илгээж, мөн эрх чөлөөгөө хадгалах хүсэлтэй бүх хүмүүсийг, амаликаячууд гэж нэрлэн Амаликая мөн тэрсэлсэн тэдний эсрэг зогсоохоор нэгтгэн цуглуулав.

Moroni said unto them: Behold, we are a remnant of the seed of Jacob; yea, we are a remnant of the seed of Joseph, whose coat was rent by his brethren into many pieces; yea, and now behold, let us remember to keep the commandments of God, or our garments shall be rent by our brethren, and we be cast into prison, or be sold, or be slain.

Yea, let us preserve our liberty as a remnant of Joseph; yea, let us remember the words of Jacob, before his death, for behold, he saw that a part of the remnant of the coat of Joseph was preserved and had not decayed. And he said—Even as this remnant of garment of my son hath been preserved, so shall a remnant of the seed of my son be preserved by the hand of God, and be taken unto himself, while the remainder of the seed of Joseph shall perish, even as the remnant of his garment.

Now behold, this giveth my soul sorrow; neverthe- less, my soul hath joy in my son, because of that part of his seed which shall be taken unto God.

Now behold, this was the language of Jacob.

And now who knoweth but what the remnant of the seed of Joseph, which shall perish as his garment, are those who have dissented from us? Yea, and even it shall be ourselves if we do not stand fast in the faith of Christ.

And now it came to pass that when Moroni had said these words he went forth, and also sent forth in all the parts of the land where there were dissensions, and gathered together all the people who were desirous to maintain their liberty, to stand against Amalickiah and those who had dissented, who were called Amalickiahites.

29 Мөнхүү улиран тохиох дор Амаликая Моронайн хүмүүсийг амаликаячуудаас илүү олон тоотойг хараад—мөн өөрийнх нь хүмүүс эхлүүлсэн хөдөлгөөнийхөө шударга эсэх талаар эргэлзэж буйг тэрээр түүнчлэн үзэв—тиймийн тул, зорьсондоо хүрэхгүй байх хэмээн айсны учир, тэрээр өөрийн хүмүүсээс өөртэй нь хамт явах тэднийг авч мөн Нифайн нутаг тийш одов.

30 Эдүгээ Моронай леменчүүд илүү хүчийг авах нь зохистой бус хэмээн боджээ; тиймийн тул тэрээр Амаликаягийн хүмүүсийг зогсоох, эсвээс тэднийг гүйцэж мөн буцаан авчрах, мөн Амаликаяг үхэлд хүргэхээр бодсон ажээ; тийм ээ, учир нь өөрсдийнх нь эсрэг уурлуулахаар леменчүүдийг Амаликая өдөөн хатгаж, мөн өөрсдийнх нь эсрэг тулалдахаар ирэхэд тэднийг хүргэнэ гэдгийг тэр мэдэж байв; мөн Амаликая зорилгодоо хүрч болохын тулд үүнийг хийнэ гэдгийг тэр мэдэж байв.

31 Тиймийн тул Моронай нэгдэн цугларсан, мөн өөрсдийгөө зэвсэглэж энхийг сахих гэрээнд орсон их цэргээ авбал зохино хэмээн бодсон ажээ—мөн улиран тохиох дор тэрээр их цэргээ авч мөн майхнуудтайгаа аглаг буйд дахь Амаликаягийн замыг хааж зогсоохоор аглаг буйд тийш жагсан одов.

32 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүслийнхээ дагуу хийж, мөн аглаг буйдад жагсан алхсаар, мөн Амаликаягийн их цэргийг гүйцэв.

33 Мөн улиран тохиох дор Амаликая өөрийн хүмүүсээс цөөн хэдтэй нь зугтаж мөн үлдсэн нь Моронайн гарт орж мөн Зарахемла нутагт буцаан хүргэгдэв.

34 Эдүгээ, Моронай ерөнхий шүүгчдээр мөн хүмүүсийн дуу хоолойгоор томилогдсон хүн байсан учир, тиймийн тул тааллынхаа дагуу нифайчуудын их цэргийн дээр эрх мэдлээ зарлаж мөн үзүүлэх хүч түүнд байв.

35 Мөнхүү улиран тохиох дор амаликаячуудаас тэд чөлөөт засаглалыг дэмжиж болохын тулд, эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжих гэрээнд орохгүй байсан хэнийг боловч, үхэлд хүргэгдэх болгов; мөн эрх чөлөөний гэрээнээс татгалзсан нь цөөн хэдхэн байв.

And it came to pass that when Amalickiah saw that the people of Moroni were more numerous than the Amalickiahites—and he also saw that his people were doubtful concerning the justice of the cause in which they had undertaken—therefore, fearing that he should not gain the point, he took those of his people who would and departed into the land of Nephi.

Now Moroni thought it was not expedient that the Lamanites should have any more strength; therefore he thought to cut off the people of Amalickiah, or to take them and bring them back, and put Amalickiah to death; yea, for he knew that he would stir up the Lamanites to anger against them, and cause them to come to battle against them; and this he knew that Amalickiah would do that he might obtain his purposes.

Therefore Moroni thought it was expedient that he should take his armies, who had gathered themselves together, and armed themselves, and entered into a covenant to keep the peace—and it came to pass that he took his army and marched out with his tents into the wilderness, to cut off the course of Amalickiah in the wilderness.

And it came to pass that he did according to his desires, and marched forth into the wilderness, and headed the armies of Amalickiah.

And it came to pass that Amalickiah fled with a small number of his men, and the remainder were delivered up into the hands of Moroni and were taken back into the land of Zarahemla.

Now, Moroni being a man who was appointed by the chief judges and the voice of the people, therefore he had power according to his will with the armies of the Nephites, to establish and to exercise authority over them.

And it came to pass that whomsoever of the Amalickiahites that would not enter into a covenant to support the cause of freedom, that they might maintain a free government, he caused to be put to death; and there were but few who denied the covenant of freedom.

- 36 Мөнхүү улиран тохиох дор, түүнчлэн тэр нифайчуудаар эзэмшигдэж байсан тэр бүх нутаг даяар цамхаг болгон дээр эрх чөлөөний туг өргөгдөх болгов; мөн ийн Моронай эрх чөлөөний далбааг нифайчуудын дунд босгов.
- 37 Мөн уг нутагт тэд дахин энх амгалан байж эхлэв; мөн тийн тэд бараг шүүгчдийн засаглалын арван есдүгээр оны эцсийг хүртэл уг нутагт энх амгаланг хадгалав.
- 38 Мөн Хиламан болон дээд санваартнууд түүнчлэн сүм дэх журмыг хадгалав; тийм ээ, бүр дөрвөн жилийн турш сүмийн дотор тэдэнд их амгалан мөн баясал байв.
- 39 Мөнхүү улиран тохиох дор тэдний сүнснүүд Их Эзэн Есүс Христээр гэтэлгэгдсэн хэмээн хатуу итгэсээр үхсэн нь олон байв; тийн тэд баяссаар дэлхийгээс одов.
- 40 Мөн зарим нь, жилийн зарим улиралд уг нутагт маш ойр ойрхон тохиолддог халуунаас үхэв—гэвч төдий олон нь халуунаас болсонгүй, учир нь цаг агаарын учир хүмүүний тусах өвчний эх үүсвэрийг зайлуулахаар Бурханы бэлтгэсэн олон ургамал мөн үндсүүдийн онц сайн чанартайгаас буюу—
- 41 Харин насны өндрөөс үхсэн нь олон байв; мөн Христэд итгэсээр наснаас хальсан тэд түүнтэй хамт аз жаргалтай байгаа, бид тийн бодох ёстой.

And it came to pass also, that he caused the title of liberty to be hoisted upon every tower which was in all the land, which was possessed by the Nephites; and thus Moroni planted the standard of liberty among the Nephites.

And they began to have peace again in the land; and thus they did maintain peace in the land until nearly the end of the nineteenth year of the reign of the judges.

And Helaman and the high priests did also maintain order in the church; yea, even for the space of four years did they have much peace and rejoicing in the church.

And it came to pass that there were many who died, firmly believing that their souls were redeemed by the Lord Jesus Christ; thus they went out of the world rejoicing.

And there were some who died with fevers, which at some seasons of the year were very frequent in the land—but not so much so with fevers, because of the excellent qualities of the many plants and roots which God had prepared to remove the cause of diseases, to which men were subject by the nature of the climate—

But there were many who died with old age; and those who died in the faith of Christ are happy in him, as we must needs suppose.

## Алма 47

- 1 Эдүгээ бид Амаликая болон түүнтэй хамт аглаг буйд тийш зугтсан тэдний цэдэгт эргэн орцгооё; учир нь, болгоогтун, тэрээр өөртэйгөө явсан тэднийг авч, мөн Нифайн нутагт леменчүүдийн дунд одсон байв, мөн Нифайн хүмүүсийн эсрэг уурлуулахаар леменчүүдийг өдөөн хатгав, үүний хэрээр леменчүүдийн хаан өөрийн бүх нутаг даяар, өөрийн бүх хүмүүсийн дунд, тэд нифайчуудын эсрэг тулалдахаар явахын тулд дахин нэгдэн цугларцгаа хэмээн зар илгээв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд зар түгэхэд тэд үлэмж айв; тийм ээ, тэд хааны дургүйцлийг хүргэхээс айв, мөн түүнчлэн тэд амиа алдах болов хэмээн Нифайчуудын эсрэг тулалдахаар явахаасаа айсан ажээ. Мөнхүү улиран тохиох дор тэд, эсвээс тэдний ихэнх хэсэг нь хааны зарлигуудыг дагах хүсэлгүй байв.
- 3 Мөн эдүгээ улиран тохиох дор тэдний дуулгаваргүй байдлын учир хаан хилэгнэв; тиймийн тул тэрээр өөрийн зарлигуудад дуулгавартай байсан их цэргийнхээ тэр хэсгийн удирдлагыг Амаликайд өгч, мөн явж мөн тэднийг зэвсэглэхийг албадахыг түүнд зарлиглав.
- 4 Эдүгээ болгоогтун, энэ нь Амаликаягийн хүсэл байв; учир нь тэр хилэнцийг хийхдээ маш зальтай хүн байсан учир, тиймийн тул леменчүүдийн хааныг сэнтийнээс нь буулгах төлөвлөгөөг тэр зүрх сэтгэлдээ агуулж байв.
- 5 Мөн эдүгээ тэрээр хааны талд байсан леменчүүдийн тэдгээр хэсгүүдийн удирдлагыг авав; мөн тэр дуулгаваргүй байсан тэдний тааллыг олохыг эрэлхийлж байв; тиймийн тул бүх леменчүүд гийшээ зугтсан учир, Онида гэж нэрлэгдсэн газар тэрээр очив; тэд их цэрэг ирж явааг олж мэдсэний учир, мөн өөрсдийг нь устгахаар тэд ирж буй хэмээн бодод, тиймийн тул тэд Онидагийн зүг, зэвсэглэх газрынхаа зүг зугтсан ажээ.
- 6 Мөн тэд өөрсдийн дээр хаан мөн удирдагч байх хүнийг томилсон байв, тэд нифайчуудын эсрэг явахад хамрагдахгүй хэмээн хатуу шийдэмгийгээр сэтгэл оюунаа хандуулсан байсны учир болой.

## Alma 47

Now we will return in our record to Amalickiah and those who had fled with him into the wilderness; for, behold, he had taken those who went with him, and went up in the land of Nephi among the Lamanites, and did stir up the Lamanites to anger against the people of Nephi, insomuch that the king of the Lamanites sent a proclamation throughout all his land, among all his people, that they should gather themselves together again to go to battle against the Nephites.

And it came to pass that when the proclamation had gone forth among them they were exceedingly afraid; yea, they feared to displease the king, and they also feared to go to battle against the Nephites lest they should lose their lives. And it came to pass that they would not, or the more part of them would not, obey the commandments of the king.

And now it came to pass that the king was wroth because of their disobedience; therefore he gave Amalickiah the command of that part of his army which was obedient unto his commands, and commanded him that he should go forth and compel them to arms.

Now behold, this was the desire of Amalickiah; for he being a very subtle man to do evil therefore he laid the plan in his heart to dethrone the king of the Lamanites.

And now he had got the command of those parts of the Lamanites who were in favor of the king; and he sought to gain favor of those who were not obedient; therefore he went forward to the place which was called Onidah, for thither had all the Lamanites fled; for they discovered the army coming, and, supposing that they were coming to destroy them, therefore they fled to Onidah, to the place of arms.

And they had appointed a man to be a king and a leader over them, being fixed in their minds with a determined resolution that they would not be subjected to go against the Nephites.

- 7 Мөнхүү улиран тохиох дор тэд тулалдахаар бэлтгэж, Антипас гэж нэрлэгдсэн уулын орой дээр өөрсдөө цугларцгаасан байв.
- 8 Эдүгээ хааны зарлигуудын дагуу тэдэнтэй тулалдах нь Амаликаягийн санаа биш байв; гэвч болгоогтун, тэрээр өөрийгөө тэдний толгойлогч болгож мөн хааныг сэнтийнээс нь буулгаж бас хаант улсын эзэмшлийг авахын тулд леменчүүдийн их цэргийн тааллыг олох нь түүний санаа байжээ.
- 9 Мөн болгоогтун, улиран тохиох дор тэрээр өөрийн их цэргийг Антипас уулын дэргэдэх хөндийд майхнуудаа босгох болгов.
- 10 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр нууц элчийг шөнөөр Антипас ууланд илгээж, уулан дээр байсан тэдний удирдагч, Лихонти гэгчээс тэр түүнтэй ярихыг хүссэн тул доош бууж уулын бэлд ирэхийг хүсэв.
- 11 Мөнхүү улиран тохиох дор Лихонти мэдээг хүлээж аваад тэрээр уулын бэл уруу бууж зүрхэлсэнгүй. Мөнхүү улиран тохиох дор Амаликая хоёр дахь удаагаа хүн илгээж, түүнийг доош бууж ирэхийг хүсэв. Мөнхүү улиран тохиох дор Лихонти тэгсэнгүй; мөн тэрээр дахин гурав дахь удаагаа илгээв.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Лихонтиг уулнаас буулган ирж чадахгүйгээ Амаликая мэдээд, тэрээр уул өөд гарч, Лихонтийн бараг л буудалд нь очив; мөн түүнийг бууж ирэхийг хүсэн тэрээр мэдээгээ Лихонтид дахин дөрөв дэх удаагаа илгээж, харуулуудаа өөртэйгөө хамт авч ирэхийг түүнээс хүсэв.
- 13 Мөнхүү улиран тохиох дор Лихонти харуулуудтайгаа хамт бууж Амаликайд ирэхэд, Амаликая түүнээс шөнийн цагаар их цэргээ аван бууж ирээд, мөн буудалд байгаа хааны түүнд захиргааг нь өгсөн тэднийг бүслэн авахыг хүсч, мөн хэрэв тэр түүнийг (Амаликаяг) бүх цэргийн дээр хоёр дахь удирдагч болговол тэр тэднийг Лихонтийн гарт оруулна хэмээв.
- 14 Мөнхүү улиран тохиох дор Лихонти эрчүүдтэйгээ бууж ирээд мөн Амаликаягийн эрчүүдийг бүслэв, иймээс үүрээр сэрэхээсээ өмнө тэд Лихонтийн их цэрэгт бүслэгдсэн байв.

And it came to pass that they had gathered themselves together upon the top of the mount which was called Antipas, in preparation to battle.

Now it was not Amalickiah's intention to give them battle according to the commandments of the king; but behold, it was his intention to gain favor with the armies of the Lamanites, that he might place himself at their head and dethrone the king and take possession of the kingdom.

And behold, it came to pass that he caused his army to pitch their tents in the valley which was near the mount Antipas.

And it came to pass that when it was night he sent a secret embassy into the mount Antipas, desiring that the leader of those who were upon the mount, whose name was Lehonti, that he should come down to the foot of the mount, for he desired to speak with him.

And it came to pass that when Lehonti received the message he durst not go down to the foot of the mount. And it came to pass that Amalickiah sent again the second time, desiring him to come down. And it came to pass that Lehonti would not; and he sent again the third time.

And it came to pass that when Amalickiah found that he could not get Lehonti to come down off from the mount, he went up into the mount, nearly to Lehonti's camp; and he sent again the fourth time his message unto Lehonti, desiring that he would come down, and that he would bring his guards with him.

And it came to pass that when Lehonti had come down with his guards to Amalickiah, that Amalickiah desired him to come down with his army in the nighttime, and surround those men in their camps over whom the king had given him command, and that he would deliver them up into Lehonti's hands, if he would make him (Amalickiah) a second leader over the whole army.

And it came to pass that Lehonti came down with his men and surrounded the men of Amalickiah, so that before they awoke at the dawn of day they were surrounded by the armies of Lehonti.

15 Мөнхүү улиран тохиох дор бүслэгдсэнээ тэд хараад, тэд устгагдахгүйн тулд ах дүүстэйгээ нэгдэхийг зөвшөөрөхийг тэд Амаликаягаас гуйв. Эдүгээ энэ нь Амаликаягийн хүссэн чухам тэр зүйл байв.

16 Мөнхүү улиран тохиох дор тэр хааны зарлигуудын эсрэгээр өөрийн хүмүүсийг мэдэлд нь өгөв. Эдүгээ хааныг сэнтийнээс нь буулгах аргаа тэрээр хэрэгжүүлж болохын тулд, Амаликаягийн хүссэн тэр зүйл нь энэ байв.

17 Эдүгээ хэрэв тэдний ерөнхий удирдагч нь алагдвал, хоёр дахь удирдагчийг өөрсдийн ерөнхий удирдагчаар томилох нь леменчүүдийн дундах заншил байв.

18 Мөнхүү улиран тохиох дор Амаликая өөрийн зарц нарын нэгээр Лихонтид бага багаар хор өгүүлж, ингээд тэр үхэв.

19 Эдүгээ, Лихонтиг үхсэний дараа, леменчүүд Амаликаяг өөрсдийн удирдагч бөгөөд ерөнхий захирагчаа байхаар томилов.

20 Мөнхүү улиран тохиох дор Амаликая их цэрэгтэйгээ (учир нь тэр хүслээ гүйцээсэн бөлгөө) Нифайн нутаг тийш, гол хот асан тэр Нифай хотын зүг хөдлөв.

21 Мөн хаан түүнтэй уулзахаар харуулуудтайгаа гарч ирэв, учир нь тэр Амаликаяг өөрийнх нь зарлигуудыг биелүүлсэн, мөн Амаликая Нифайчуудын эсрэг тулалдахаар явах ийм агуу олноор их цэргийг нэгтгэн цуглуулсан хэмээн боджээ.

22 Гэвч болгоогтун, хаан түүнтэй уулзахаар гарч ирэхэд Амаликая зарц нараа хаантай уулзуулахаар явуулав. Мөн тэд очиж мөн хааны өмнө түүний агуу ихийн учир түүнийг бишрэн хүндэтгэх мэт бөхийв.

23 Мөнхүү улиран тохиох дор тэдний нифайчуудаас авсан тэдний заншил болох леменчүүдийн заншлаар, амар амгалангийн тэмдэг болгож тэднийг босгохоор хаан гараа урагш сунгав.

24 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эхний хүнийг газраас босгомгоц, болгоогтун тэрээр хааны зүрхэнд хутгалав; мөн тэрээр хөсөр ойчив.

25 Эдүгээ хааны зарц нар зугтав; мөн Амаликаягийн зарц нар дуугаа өргөн хашгирч, хэлсэн нь:

And it came to pass that when they saw that they were surrounded, they pled with Amalickiah that he would suffer them to fall in with their brethren, that they might not be destroyed. Now this was the very thing which Amalickiah desired.

And it came to pass that he delivered his men, contrary to the commands of the king. Now this was the thing that Amalickiah desired, that he might accomplish his designs in dethroning the king.

Now it was the custom among the Lamanites, if their chief leader was killed, to appoint the second leader to be their chief leader.

And it came to pass that Amalickiah caused that one of his servants should administer poison by degrees to Lehonti, that he died.

Now, when Lehonti was dead, the Lamanites appointed Amalickiah to be their leader and their chief commander.

And it came to pass that Amalickiah marched with his armies (for he had gained his desires) to the land of Nephi, to the city of Nephi, which was the chief city.

And the king came out to meet him with his guards, for he supposed that Amalickiah had fulfilled his commands, and that Amalickiah had gathered together so great an army to go against the Nephites to battle.

But behold, as the king came out to meet him Amalickiah caused that his servants should go forth to meet the king. And they went and bowed themselves before the king, as if to reverence him because of his greatness.

And it came to pass that the king put forth his hand to raise them, as was the custom with the Lamanites, as a token of peace, which custom they had taken from the Nephites.

And it came to pass that when he had raised the first from the ground, behold he stabbed the king to the heart; and he fell to the earth.

Now the servants of the king fled; and the servants of Amalickiah raised a cry, saying:

26 Болгоогтун, хааны зарц нар түүнийг зүрхэнд хутгалав, мөн тэр унаж мөн тэд зугтав; болгоогтун, ирж мөн хар.

27 Мөнхүү улиран тохиох дор Амаликая өөрийн цэргийг урагш алхалж мөн хаанд юу тохиолдсоныг хар хэмээн зарлиглав; мөн тэд уг газар ирэхэд, мөн хаан цусандаа хутгалдан хэвтэж буйг олоход, Амаликая хилэгнэж буй дүр үзүүлж, мөн хэлэв: Хаанд хайртай байсан хэн боловч, явж мөн түүний зарц нарыг тэд алагдахын тулд мөрдөн хөөг.

28 Мөнхүү улиран тохиох дор хааныг хайрладаг байсан тэд эдгээр үгийг сонсоод урагш одож мөн хааны зарц нарын араас мөшгөн хөөв.

29 Эдүгээ хааны зарц нар их цэрэг тэдний араас мөрдөн айсууг хараад, тэд дахин айж, мөн аглаг буйд тийш зугтав, мөн Зарахемла нутагт ирж мөн Аммоны хүмүүстэй нэгдэв.

30 Мөн тэдний араас мөрдсөн их цэрэг, тэдний араас хоосон мөрдөөд буцаж ирэв; мөн тийн Амаликая, заль мэхээрээ хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдэв.

31 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь тэр Нифайн хотод их цэргийнхээ хамт орж, мөн хотын эзэмшлийг авав.

32 Мөн эдүгээ улиран тохиох дор хатан, хаан алагдсаныг сонсоод—учир нь хаан зарц нартаа алагдаж, Амаликая тэднийг их цэрэгтэйгээ мөрдсөн боловч энэ нь хоосон байж мөн тэд оргон зайлж амжсаныг түүнд мэдээлэн тэрээр хатанд элч илгээсэн ажээ—

33 Тиймийн тул, хатан энэ мэдээг хүлээн аваад Амаликаяд илгээж, хотын хүмүүсийг өршөөн хэлтрүүлэхийг түүнээс хүсэв; мөн түүнчлэн тэр эмэгтэй өөр дээрээ ирэхийг хүсэв; мөн түүнчлэн тэр эмэгтэй хааны үхлийн талаар гэрчлэх гэрчүүдийг өөртэйгөө хамт авчрахыг түүнээс хүсэв.

Behold, the servants of the king have stabbed him to the heart, and he has fallen and they have fled; behold, come and see.

And it came to pass that Amalickiah commanded that his armies should march forth and see what had happened to the king; and when they had come to the spot, and found the king lying in his gore, Amalickiah pretended to be wroth, and said: Whosoever loved the king, let him go forth, and pursue his servants that they may be slain.

And it came to pass that all they who loved the king, when they heard these words, came forth and pursued after the servants of the king.

Now when the servants of the king saw an army pursuing after them, they were frightened again, and fled into the wilderness, and came over into the land of Zarahemla and joined the people of Ammon.

And the army which pursued after them returned, having pursued after them in vain; and thus Amalickiah, by his fraud, gained the hearts of the people.

And it came to pass on the morrow he entered the city Nephi with his armies, and took possession of the city.

And now it came to pass that the queen, when she had heard that the king was slain—for Amalickiah had sent an embassy to the queen informing her that the king had been slain by his servants, that he had pursued them with his army, but it was in vain, and they had made their escape—

Therefore, when the queen had received this message she sent unto Amalickiah, desiring him that he would spare the people of the city; and she also desired him that he should come in unto her; and she also desired him that he should bring witnesses with him to testify concerning the death of the king.



34 Мөнхүү улиран тохиох дор Амаликая хааныг алсан тэрхүү зарцыг, мөн түүнтэй хамт байсан тэд бүгдийг авч, мөн хатанд, түүний сууж байсан газар очив; мөн тэд бүгд хаан зарц нартаа алагдсаныг түүнд гэрчлэв; мөн түүнчлэн тэд хэлэв: Тэд зугтсан; энэ нь тэдний эсрэг гэрчлэхгүй байна гэж үү? Мөн тийн хааны үхлийн талаарх хатны эргэлзээг тэд арилгав.

35 Мөнхүү улиран тохиох дор Амаликая хатны тааллыг эрэлхийлж, мөн түүнийг өөртөө эхнэр болгон авав; мөн тийн заль мэхээрээ, мөн башир аргат зарц нарынхаа туслалцаатайгаар, тэр хаант улсыг эзлэв; тийм ээ, тэр бүх нутаг даяар, леменчүүд мөн лемүүлчүүд мөн ишмэйлчүүдээс мөн Нифайн засаглалаас одоог хүртэлх нифайчуудын бүх тэрслэгчдээс бүрдсэн тэр бүх леменчүүдийн ард түмний дунд хаан хэмээн хүлээн зөвшөөрөгдөв.

36 Эдүгээ эдгээр тэрслэгчид нь, нифайчуудын нэгэн адил заавар мөн нэгэн адил мэдээллийг авсан байв, тийм ээ, Их Эзэний тухай нэг адил мэдлэгт сургагдсан байлаа, гэсэн хэдий ч тэрслэснийхээ дараа тэд тун удалгүй леменчүүдээс ч илүү хатуу мөн гэмшдэггүй, мөн илүү зэрлэг, ёс бус мөн догшин хэрцгий болцгоосон байсныг дурдах нь хачирхалтай юм—леменчүүдийн зан заншилд уусаж; залхуу байдалдаа мөн бүх төрлийн тачаангуйлалд автагдсан байв; тийм ээ, Их Эзэн Бурханаа бүрмөсөн мартсан байв.

And it came to pass that Amalickiah took the same servant that slew the king, and all them who were with him, and went in unto the queen, unto the place where she sat; and they all testified unto her that the king was slain by his own servants; and they said also: They have fled; does not this testify against them? And thus they satisfied the queen concerning the death of the king.

And it came to pass that Amalickiah sought the favor of the queen, and took her unto him to wife; and thus by his fraud, and by the assistance of his cunning servants, he obtained the kingdom; yea, he was acknowledged king throughout all the land, among all the people of the Lamanites, who were composed of the Lamanites and the Lemuelites and the Ishmaelites, and all the dissenters of the Nephites, from the reign of Nephi down to the present time.

Now these dissenters, having the same instruction and the same information of the Nephites, yea, having been instructed in the same knowledge of the Lord, nevertheless, it is strange to relate, not long after their dissensions they became more hardened and impenitent, and more wild, wicked and ferocious than the Lamanites—drinking in with the traditions of the Lamanites; giving way to indolence, and all manner of lasciviousness; yea, entirely forgetting the Lord their God.

## Алма 48

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор, Амаликая хаант улсыг авмагцаа леменчүүдийн зүрх сэтгэлийг Нифайн хүмүүсийн эсрэг дэвэргэж эхлэв; тийм ээ, цамхгууд дээрээсээ нифайчуудын эсрэг ярих хүмүүсийг тэр леменчүүдэд томилсон болой.
- 2 Мөн тийн тэр тэдний зүрх сэтгэлийг нифайчуудын эсрэг дэвэргэж, үүний хэрээр шүүгчдийн засаглалын арван ес дэх оны төгсгөлд, тэрээр өдийг хүртэл өөрийн төлөвлөгөөнүүдийг гүйцэлдүүлсэн учир, тийм ээ, леменчүүдийн дээр хаан болгогдсон учир, тэр бүх нутгийн дээр, тийм ээ, мөн уг нутагт байсан бүх хүмүүсийн дээр, леменчүүдийн нэг адил нифайчуудын дээр түүнчлэн засаглахыг эрэлхийлсэн бөлгөө.
- 3 Тиймийн тул тэр санаагаа гүйцээсэн аж, учир нь тэр леменчүүдийн зүрхийг хатууруулж мөн оюуныг нь харалган болгож, мөн уурлуулахаар тэднийг өдөөн хатгаж, үүний хэрээр тэр нифайчуудын эсрэг тулалдахаар явах олон тооны дайчдыг нэгтгэн цуглуулсан байв
- 4 Учир нь тэр, өөрийн хүмүүсийн тооны ихийн учир, нифайчуудыг давамгайлж мөн тэднийг дарангуйлалд авчрахаар шийдсэн байлаа.
- 5 Мөн тийн тэрээр зорамчуудаас ерөнхий ахмадуудыг томилов, учир нь нифайчуудын хүч чадал, мөн тэдний хоргодох газрууд, мөн хотуудынх нь хамгийн хүч султай хэсгүүдийг сайн мэддэг байсан нь тэд байв; тиймийн тул тэрээр тэднийг их цэргийнхээ дээр ерөнхий ахмадууд байхаар томилов.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн буудлыг авч, мөн Зарахемла нутгийн зүг аглаг буйдад нүүдэллэв.
- 7 Эдүгээ улиран тохиох дор Амаликая ийн заль мэх мөн луйвраар хүчийг олж байхад, нөгөө талд, Моронай хүмүүсийн оюуныг Их Эзэн Бурхандаа итгэлтэй байхад бэлтгэж байв.

## Alma 48

And now it came to pass that, as soon as Amalickiah had obtained the kingdom he began to inspire the hearts of the Lamanites against the people of Nephi; yea, he did appoint men to speak unto the Lamanites from their towers, against the Nephites.

And thus he did inspire their hearts against the Nephites, insomuch that in the latter end of the nineteenth year of the reign of the judges, he having accomplished his designs thus far, yea, having been made king over the Lamanites, he sought also to reign over all the land, yea, and all the people who were in the land, the Nephites as well as the Lamanites.

Therefore he had accomplished his design, for he had hardened the hearts of the Lamanites and blinded their minds, and stirred them up to anger, insomuch that he had gathered together a numerous host to go to battle against the Nephites.

For he was determined, because of the greatness of the number of his people, to overpower the Nephites and to bring them into bondage.

And thus he did appoint chief captains of the Zoramites, they being the most acquainted with the strength of the Nephites, and their places of resort, and the weakest parts of their cities; therefore he appointed them to be chief captains over his armies.

And it came to pass that they took their camp, and moved forth toward the land of Zarahemla in the wilderness.

Now it came to pass that while Amalickiah had thus been obtaining power by fraud and deceit, Moroni, on the other hand, had been preparing the minds of the people to be faithful unto the Lord their God.

- 8 Тийм ээ, тэр нифайчуудын их цэргийг хүчирхэгжүүлж, мөн жижиг бэхлэлтүүдийг, эсвээс хоргодох газруудыг босгож байв; их цэргээ халхлахаар газрын эргийг өндөрлөж, мөн түүнчлэн тэднийг тойруулан, хотуудынхаа мөн нутгийнхаа хилийг хүрээлүүлэн; тийм ээ, нутгийг бүхэлд нь хүрээлүүлэн чулуун хэрэм босгов.
- 9 Мөн өөрсдийн хамгийн хүч султай бэхлэлтэнд илүү олон тооны эрчүүдийг тэрээр байрлуулжээ; мөн тийн тэрээр нифайчуудаар эзэмшигдэж асан тэр нутгаа бэхэлж мөн хүчирхэгжүүлжээ.
- 10 Мөн тийн тэрээр тэд Их Эзэн Бурханыхаа төлөө амьдарч болохын тулд, мөн тэд дайснуудаар нь Христийнхний хөдөлгөөн гэж нэрлэгдсэн түүнийгээ хадгалж болохын тулд чөлөөт байдлаа, газар нутгаа, эхнэр, мөн хүүхдүүдээ, мөн өөрсдийн амар амгаланг хамгаалахаар бэлтгэж байв.
- 11 Мөн Моронай хүчтэй мөн чадалтай хүн байв; тэр төгс ойлголттой хүн байв; тийм ээ, цус урсалтанд баясдаггүй нэгэн байв; ах дүүс нь дарангуйлал мөн боолчлолоос чөлөөтэй байхад мөн төрөлх орныхоо чөлөөт байдал хийгээд эрх чөлөөнд бодгаль нь баясдаг хүн байв;
- 12 Тийм ээ, Бурхандаа талархах талархлаар зүрх сэтгэл нь тэлдэг хүн байв, хүмүүсийнх нь дээр түүний цутгасан олон боломжууд хийгээд адислалуудын учир болой; өөрийн хүмүүсийн аз жаргал болоод аюулгүй байдлын төлөө үлэмж хөдөлмөрлөдөг хүн байв.
- 13 Тийм ээ, мөн тэрээр Христийн итгэлд гуйвшгүй хүн байв; мөн тэрээр ард түмнээ, эрхүүдээ, мөн төрөлх орноо, мөн шашин шүтлэгээ, бүр өөрийн цусыг шавхах хүртлээ өмгөөлөхөөр тангараг тавьсан байв.
- 14 Эдүгээ нифайчууд дайснуудынхаа эсрэг, бүр хэрэв зайлшгүй шаардагдах аваас цус урсгах хүртлээ өөрсдийгөө хамгаалах ёстой хэмээн сургагдсан байв; тийм ээ, мөн түүнчлэн тэд хэзээ ч хэрэг төвөг өдөөхгүй, тийм ээ, мөн дайснуудынхаа эсрэг бус аваас, амиа хамгаалахаас өөрөөр хэзээ ч илд далайхгүй байх ёстой хэмээн сургагдсан байлаа.

Yea, he had been strengthening the armies of the Nephites, and erecting small forts, or places of resort; throwing up banks of earth round about to enclose his armies, and also building walls of stone to encircle them about, round about their cities and the borders of their lands; yea, all round about the land.

And in their weakest fortifications he did place the greater number of men; and thus he did fortify and strengthen the land which was possessed by the Nephites.

And thus he was preparing to support their liberty, their lands, their wives, and their children, and their peace, and that they might live unto the Lord their God, and that they might maintain that which was called by their enemies the cause of Christians.

And Moroni was a strong and a mighty man; he was a man of a perfect understanding; yea, a man that did not delight in bloodshed; a man whose soul did joy in the liberty and the freedom of his country, and his brethren from bondage and slavery;

Yea, a man whose heart did swell with thanksgiving to his God, for the many privileges and blessings which he bestowed upon his people; a man who did labor exceedingly for the welfare and safety of his people.

Yea, and he was a man who was firm in the faith of Christ, and he had sworn with an oath to defend his people, his rights, and his country, and his religion, even to the loss of his blood.

Now the Nephites were taught to defend themselves against their enemies, even to the shedding of blood if it were necessary; yea, and they were also taught never to give an offense, yea, and never to raise the sword except it were against an enemy, except it were to preserve their lives.

- 15 Мөн тэдний итгэл ийм байв; үүнчлэн үйлдсэнээр Бурхан тэднийг уг нутагт дэгжүүлнэ эсвээс өөрөөр хэлбэл, хэрэв тэд Бурханы зарлигуудыг дагахдаа итгэлтэй байвал, тэрээр уг нутагт тэднийг дэгжүүлэх болно; тийм ээ, тэдэнд аюултайнх нь дагуу, тэдэнд зугтахыг, эсвээс дайнд бэлтгэхийг сэрэмжлүүлэх бөлгөө;
- 16 Мөн түүнчлэн, дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө хамгаалахаар тэдний хааш одох ёстойг Бурхан тэдэнд мэдүүлнэ, мөн ингэснээр, Их Эзэн тэднийг чөлөөлөх буюу; мөн энэ нь Моронайн итгэл байв, мөн зүрх сэтгэл нь үүнд баясдаг байв; цус урсгахад бус харин сайныг үйлдэхэд, өөрийн хүмүүсийг хадгалан хамгаалахад, тийм ээ, Бурханы зарлигуудыг дагахад, тийм ээ, мөн алдсыг эсэргүүцэхэд болой.
- 17 Тийм ээ, үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ, хэрэв бүх хүмүүн Моронайн адил байсан мөн байдаг, мөн байх аваас, болгоогтун, тамын чухамхүү хүчин чадал үүрд сэгсрэгдэн сулруулагдахсан; тийм ээ, хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг давах хүч чөтгөрт хэзээ ч байхгүй байхсан.
- 18 Болгоогтун, Мозаягийн хүү, Аммоны адил хүн, тийм ээ, бүр Мозаягийн бусад хөвгүүдийн адил, тийм ээ, мөн түүнчлэн Алма болон түүний хөвгүүдийн адил байв, учир нь тэд бүгд Бурханы хүмүүс байв.
- 19 Эдүгээ болгоогтун, Хиламан мөн түүний ах дүүс хүмүүст Моронайгаас дутуугүй үйлчилдэг байв; учир нь тэд Бурханы үгийг номлож, мөн тэд үгсийг нь сонсох хэнийг боловч бүх хүмүүсийг наманчлалд хүргэн баптисм хүртээж байлаа.
- 20 Мөн тийн тэд урагшлан явж, мөн тэдний үгсийн учир хүмүүс өөрсдийгөө даруусгаж, үүний хэрээр тэд Их Эзэний өндөр ээл хишгийг хүртэж мөн тийн өөр хоорондоо; тийм ээ, бүр дөрвөн жилийн турш дайнууд мөн зөрчлүүдээс чөлөөтэй байв.
- 21 Гэвч миний хэлсэнчлэн, арван есдүгээр оны төгсгөлд, тийм ээ, тэдний дунд энх амгалан байсан хэдий ч, тэд өөрсдийн ах дүүс, леменчүүдтэй тэмцэлдэхэд дургүй ч гэсэн албадуулагдсан болой.
- 22 Тийм ээ, мөн эцэст нь, тэд маш их дургүй байсан хэдий ч, леменчүүдтэй хийсэн тэдний дайнууд олон жилийн турш огт зогссонгүй.

And this was their faith, that by so doing God would prosper them in the land, or in other words, if they were faithful in keeping the commandments of God that he would prosper them in the land; yea, warn them to flee, or to prepare for war, according to their danger;

And also, that God would make it known unto them whither they should go to defend themselves against their enemies, and by so doing, the Lord would deliver them; and this was the faith of Moroni, and his heart did glory in it; not in the shedding of blood but in doing good, in preserving his people, yea, in keeping the commandments of God, yea, and resisting iniquity.

Yea, verily, verily I say unto you, if all men had been, and were, and ever would be, like unto Moroni, behold, the very powers of hell would have been shaken forever; yea, the devil would never have power over the hearts of the children of men.

Behold, he was a man like unto Ammon, the son of Mosiah, yea, and even the other sons of Mosiah, yea, and also Alma and his sons, for they were all men of God.

Now behold, Helaman and his brethren were no less serviceable unto the people than was Moroni; for they did preach the word of God, and they did baptize unto repentance all men whosoever would hearken unto their words.

And thus they went forth, and the people did humble themselves because of their words, insomuch that they were highly favored of the Lord, and thus they were free from wars and contentions among themselves, yea, even for the space of four years.

But, as I have said, in the latter end of the nineteenth year, yea, notwithstanding their peace amongst themselves, they were compelled reluctantly to contend with their brethren, the Lamanites.

Yea, and in fine, their wars never did cease for the space of many years with the Lamanites, notwithstanding their much reluctance.

23 Эдүгээ, тэд леменчүүдийн эсрэг зэвсэглэхэд харамсаж байв, учир юун гэвэл цус урсахад тэд баясдаг байсангүй; тийм ээ, мөн энэ нь бүгд бус—тэд ах дүүсээсээ тийм олныг нь Бурхантай уулзах бэлтгэлгүйгээр, энэ дэлхийгээс мөнхийн оронд илгээх хэрэгсэл болж байгаадаа харамсаж байлаа.

24 Гэсэн хэдий ч, тэд амиа тавьж өгөхийг хүлцэж чадсангүй, нэгэн цагт ах дүүс нь байсан, тийм ээ, мөн өөрсдийн сүмээс тэрсэлсэн, мөн тэднийг орхиж мөн леменчүүдтэй нэгдсэнээр тэднийг устгахаар одсон тэдний харгис хэрцгийлэлд эхнэр хүүхдүүд нь хядагдах байсны учир буюу.

25 Тийм ээ, Бурханы зарлигуудыг дагадаг хэн нэгэн байх цагт, ах дүүс нь нифайчуудын цусыг шавхахдаа баясахыг тэд тэвчиж чадсангүй, учир нь, хэрэв тэд түүний зарлигуудыг дагах аваас тэд уг нутагт дэгжих болно хэмээх Их Эзэний амлалт байв.

Now, they were sorry to take up arms against the Lamanites, because they did not delight in the shedding of blood; yea, and this was not all—they were sorry to be the means of sending so many of their brethren out of this world into an eternal world, unprepared to meet their God.

Nevertheless, they could not suffer to lay down their lives, that their wives and their children should be massacred by the barbarous cruelty of those who were once their brethren, yea, and had dissented from their church, and had left them and had gone to destroy them by joining the Lamanites.

Yea, they could not bear that their brethren should rejoice over the blood of the Nephites, so long as there were any who should keep the commandments of God, for the promise of the Lord was, if they should keep his commandments they should prosper in the land.

## Алма 49

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор арван есдүгээр оны арван нэгдүгээр сард, уг сарын арав дахь өдөр, леменчүүдийн их цэрэг Аммонайха нутгийн зүг ойртож буй нь харагдав.
- 2 Мөн болгоогтун, уг хот сэргээн босгогдсон байв, мөн Моронай хотын хилийн дагуу их цэргийг байрлуулсан ажгуу, мөн тэд леменчүүдийн сум мөн чулуунаас өөрсдийгөө халхлах гэж шороогоор тойруулан хаалт болгосон байв; учир нь болгоогтун тэд чулуугаар мөн нум сумаар байлддаг байжээ.
- 3 Болгоогтун би Аммонайха хот сэргээн босгогдсоныг хэлэв. Би та нарт хэлнэ, тийм ээ, энэ нь хэсэгчлэн сэргээн босгогдсон байлаа; мөн хүмүүсийнх нь алдсын учир леменчүүд үүнийг нэгэнтээ устгасан учир, энэ нь тэдний хувьд дахин амархан олз болно хэмээн тэд бодсон ажгуу.
- 4 Гэвч болгоогтун тэдний гутрал хичнээн агуу байв; учир нь болгоогтун, леменчүүд өөрсдийн чулууг мөн сумнуудаа үр дүнтэйгээр тэдний дээр буулгаж, бас орц газраар бус аваас тэдэн дээр ирж чадахааргүй тийм өндөрт нифайчууд өөрсдийгөө тойруулан шороогоор далан босгожээ.
- 5 Эдүгээ энэ үед хориглох газруудаа бэлтгэхэд гаргасан нифайчуудын мэргэн ухааны учир леменчүүдийн ерөнхий ахмадууд үлэмж гайхан цочирдсон аж.
- 6 Эдүгээ леменчүүдийн удирдагчид өөрсдийнх нь тоо агуу олны учир ийн бодсон байв, тийм ээ, тэд урьд нь тэгж байсныхаа адил тэднийг даван ирэх боломжтой байх болно хэмээн бодсон ажгуу; тийм ээ, мөн түүнчлэн тэд өөрсдийгөө бамбай мөн цээжний хуягуудтайгаар бэлтгэсэн байв; мөн түүнчлэн тэд өөрсдийгөө арьсан өмсгөлүүдтэйгээр, тийм ээ, нүцгэнийг нь халхалсан маш зузаан өмсгөлүүд тэйгээр бэлтгэсэн байв.
- 7 Мөн тийн бэлтгэснээс өөрсдийн тааллын дагуу тэд ах дүүсээ амархан давамгайлж мөн дарангуйлын буулганд харьяалуулж, эсвээс тэднийг алж мөн хядах болно хэмээн боджээ.

## Alma 49

And now it came to pass in the eleventh month of the nineteenth year, on the tenth day of the month, the armies of the Lamanites were seen approaching towards the land of Ammonihah.

And behold, the city had been rebuilt, and Moroni had stationed an army by the borders of the city, and they had cast up dirt round about to shield them from the arrows and the stones of the Lamanites; for behold, they fought with stones and with arrows.

Behold, I said that the city of Ammonihah had been rebuilt. I say unto you, yea, that it was in part rebuilt; and because the Lamanites had destroyed it once because of the iniquity of the people, they supposed that it would again become an easy prey for them.

But behold, how great was their disappointment; for behold, the Nephites had dug up a ridge of earth round about them, which was so high that the Lamanites could not cast their stones and their arrows at them that they might take effect, neither could they come upon them save it was by their place of entrance.

Now at this time the chief captains of the Lamanites were astonished exceedingly, because of the wisdom of the Nephites in preparing their places of security.

Now the leaders of the Lamanites had supposed, because of the greatness of their numbers, yea, they supposed that they should be privileged to come upon them as they had hitherto done; yea, and they had also prepared themselves with shields, and with breastplates; and they had also prepared themselves with garments of skins, yea, very thick garments to cover their nakedness.

And being thus prepared they supposed that they should easily overpower and subject their brethren to the yoke of bondage, or slay and massacre them according to their pleasure.

- 8 Гэвч болгоогтун, тэднийг бүрмөсөн гайхан цочирдуулсан нь, тэднийг ирэхэд тэд Лихайн үрсийн дунд хэзээ ч мэдэгдээгүй тийм маягаар бэлтгэгчхсэн байв. Эдүгээ тэд леменчүүдийг ирэхэд Моронайн заавруудын дагуу тулалдахаар бэлтгэсэн байв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд, өөрөөр хэлбэл амаликаячууд, тэдний дайнд бэлтгэсэн маягийг хараад үлэмж гайхан цочирдов.
- 10 Эдүгээ хэрэв Нифайн нутгаас, их цэргээ толгойлон хаан Амаликая ирсэн бол, тэрээр магад леменчүүдийг Аммонайха хот дахь нифайчуудыг довтлохыг албадах байсан буйза; учир нь болгоогтун, тэр өөрийн хүмүүсийн цусыг ч үл хайхрах ажээ.
- 11 Гэвч болгоогтун, Амаликая өөрөө тулалдахаар ирээгүй байжээ. Мөн болгоогтун, түүний ерөнхий ахмад Аммонайха хот дахь нифайчуудыг довтолж зүрхэлсэнгүй, учир нь Моронай нифайчуудын дундах үйл хэргүүдийг удирдах аргыг өөрчилж, үүний хэрээр леменчүүд тэдний хориглох газруудынх нь учир гутарч мөн тэр тэдний дээр ирж эс чадав.
- 12 Тиймийн тул тэд аглаг буйд тийш ухарч, мөн буудлаа авч мөн тэдний хувьд нифайчуудын эсрэг дайрах дараагийн хамгийн тохиромжтой газар байна хэмээн бодож Ноа нутгийн зүг жагсан одов.
- 13 Учир нь бүх нутгийн эргэн тойрон хот болгонд Моронай бэхэлснийг, өөрөөр хэлбэл хамгаалах бэхлэлтүүд барьсныг тэд мэдсэнгүй; тиймийн тул, тэд зориг шийдэмгийгээр Ноа нутгийн зүг жагсан явцгаав; тийм ээ, тэдний ерөнхий ахмадууд урагшилж мөн тэд уг хотын хүмүүсийг устгах болно хэмээн тангараг тавив.
- 14 Гэвч болгоогтун, тэдний гайхшралыг төрүүлсэн нь, Ноагийн хот, урьд нь хүчээр дорой газар байсан тэр нь, эдүгээ Моронайн тусламжтайгаар, хүчирхэг болсон байв, тийм ээ, бүр Аммонайха хотын хүчирхгээс давуу хүчирхэг болсон байв.
- 15 Мөн эдүгээ, болгоогтун, ингэсэн нь Моронайн мэргэн ухаан байв; учир нь, тэд Аммонайха хотын дэргэд сүрдсэн аж; мөн Ноа хот одоог хүртэл нутгийн хамгийн сул дорой хэсэг байснаас, тиймийн тул тэд тулалдахаар тийш жагсан хөдлөх байх хэмээн тэр боджээ; мөн тийн энэ нь түүний хүслийн дагуу болов.

But behold, to their uttermost astonishment, they were prepared for them, in a manner which never had been known among the children of Lehi. Now they were prepared for the Lamanites, to battle after the manner of the instructions of Moroni.

And it came to pass that the Lamanites, or the Amalickiahites, were exceedingly astonished at their manner of preparation for war.

Now, if king Amalickiah had come down out of the land of Nephi, at the head of his army, perhaps he would have caused the Lamanites to have attacked the Nephites at the city of Ammonihah; for behold, he did care not for the blood of his people.

But behold, Amalickiah did not come down himself to battle. And behold, his chief captains durst not attack the Nephites at the city of Ammonihah, for Moroni had altered the management of affairs among the Nephites, insomuch that the Lamanites were disappointed in their places of retreat and they could not come upon them.

Therefore they retreated into the wilderness, and took their camp and marched towards the land of Noah, supposing that to be the next best place for them to come against the Nephites.

For they knew not that Moroni had fortified, or had built forts of security, for every city in all the land round about; therefore, they marched forward to the land of Noah with a firm determination; yea, their chief captains came forward and took an oath that they would destroy the people of that city.

But behold, to their astonishment, the city of Noah, which had hitherto been a weak place, had now, by the means of Moroni, become strong, yea, even to exceed the strength of the city Ammonihah.

And now, behold, this was wisdom in Moroni; for he had supposed that they would be frightened at the city Ammonihah; and as the city of Noah had hitherto been the weakest part of the land, therefore they would march thither to battle; and thus it was according to his desires.

- 16 Мөн болгоогтун, Моронай уг хотын эрчүүдийн дээр ерөнхий ахмад болгохоор Лихайг томилсон байв; мөн энэ нь Сидон голын зүүн хөндийд леменчүүдтэй байлдсан тэрхүү Лихай байв.
- 17 Мөн эдүгээ болгоогтун улиран тохиох дор, Лихай уг хотыг захирч буйг леменчүүд олж мэдээд тэд дахин гутарцгаав, учир нь тэд Лихайгаас үлэмж айдаг ажээ; гэсэн хэдий ч тэдний ерөнхий ахмадууд уг хотыг довтлохоор тангараг тавьцгаасан байв; тиймийн тул тэд их цэргээ авчрав.
- 18 Эдүгээ болгоогтун, леменчүүд тэдний хамгаалалтын бэхлэлтүүдэд орцноос бусад газраар нэвтэрч чадсангүй, учир нь орцноос бусад газар хүрээлэн овоологдсон далангийн өндрөөс мөн ухагдсан шуудууных нь гүнээс буюу.
- 19 Мөн тийн нифайчууд өөр ямар нэгэн замаар бэхлэлтэнд орох гэж авирахаар завдсан бүгдийг, чулуугаар мөн сумаар харван устгахад бэлтгэсэн байв.
- 20 Тэд тийн бэлтгэсэн байв, тийм ээ, орц газраар хориглох байранд нь орж ирэхээр завдсан бүгдийг цохож унагахаар тэдний хамгийн хүчтэй эрчүүдийн хэсэг нь илднүүд мөн дүүгүүрүүдтэйгээ; мөн тийн тэд леменчүүдийн эсрэг өөрсдийгөө хамгаалахаар бэлтгэсэн байв.
- 21 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн ахмадууд их цэргээ орц газрын өмнө авчирч, мөн нифайчуудтай тэдний хориглох газарт нь орохоор тулалдаж эхлэв; гэвч болгоогтун, тэд цагаас цагт буцаан туугдаж, үүний хэрээр тэд асар их аллагаар хөнөөгдөв.
- 22 Эдүгээ тэд уг орц газраар нифайчуудыг давамгайлах хүчийг олж чадахгүйгээ мэдээд, тэд их цэрэгтээ гарц гаргаж болохын тулд, тэд тулалдах адил тэгш боломжтой байж болохын тулд шороон даланг нь ухаж эхлэв; гэвч болгоогтун, эдгээр завдлагадаа тэд өөрсдийнх нь дээр буулгасан чулуу мөн сумнуудаар хиар цохигдох нь тэр; мөн шуудуунуудыг нь шороон даланг буулгаж дүүргэхийн оронд, тэдгээр нь тэдний үхэгсэд мөн шархадсан биесээр тодорхой хэмжээгээр дүүргэгдсэн байв.

And behold, Moroni had appointed Lehi to be chief captain over the men of that city; and it was that same Lehi who fought with the Lamanites in the valley on the east of the river Sidon.

And now behold it came to pass, that when the Lamanites had found that Lehi commanded the city they were again disappointed, for they feared Lehi exceedingly; nevertheless their chief captains had sworn with an oath to attack the city; therefore, they brought up their armies.

Now behold, the Lamanites could not get into their forts of security by any other way save by the entrance, because of the highness of the bank which had been thrown up, and the depth of the ditch which had been dug round about, save it were by the entrance.

And thus were the Nephites prepared to destroy all such as should attempt to climb up to enter the fort by any other way, by casting over stones and arrows at them.

Thus they were prepared, yea, a body of their strongest men, with their swords and their slings, to smite down all who should attempt to come into their place of security by the place of entrance; and thus were they prepared to defend themselves against the Lamanites.

And it came to pass that the captains of the Lamanites brought up their armies before the place of entrance, and began to contend with the Nephites, to get into their place of security; but behold, they were driven back from time to time, insomuch that they were slain with an immense slaughter.

Now when they found that they could not obtain power over the Nephites by the pass, they began to dig down their banks of earth that they might obtain a pass to their armies, that they might have an equal chance to fight; but behold, in these attempts they were swept off by the stones and arrows which were thrown at them; and instead of filling up their ditches by pulling down the banks of earth, they were filled up in a measure with their dead and wounded bodies.



23 Тийнхүү дайснуудаа давах бүх хүчин нифайчуудад байв; мөн тийн леменчүүд өөрсдийн бүх ерөнхий ахмадуудыг алагдах хүртэл нифайчуудыг устгахаар оролджээ; тийм ээ, мөн леменчүүдийн мянгаас илүү нь алагдав; гэтэл, нөгөөтэйгүүр, нифайчуудаас алагдсан нэг ч бодгаль байсангүй.

24 Орц газраар леменчүүдийн суманд ил байснаас өртөж шархадсан нь тавь орчим байв, гэвч тэд бамбайнуудаараа, мөн цээжний хуяг мөн дуулгаараа халхлагдсан байлаа, үүний хэрээр тэдний шархнууд хөлөнд нь байв, тэдгээрийн олон нь маш ноцтой байжээ.

25 Мөнхүү улиран тохиох дор, леменчүүд өөрсдийн ерөнхий ахмадууд бүгд алагдсаныг хараад тэд аглаг буйд тийш зугтав. Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайн нутагт, уг гарал нь нифай үндэстэн болох тэрхүү өөрсдийн хаан, Амаликайд их алдагдлынхаа талаар мэдээлэхээр буцаж ирэв.

26 Мөнхүү улиран тохиох дор тэр, өөрийн хүмүүст үлэмж уурлаж байв нифайчуудын тухайд хүслээ гүйцээгээгүй учир; тэр тэднийг дарангуйллын буулганд харьяалуулсангүй.

27 Тийм ээ, тэр үлэмж хилэгнэж, мөн Моронайн цусыг уух болно хэмээн тангараг тавьж түүнийг мөн түүнчлэн Бурханыг зүхэв; мөн энэ нь Моронай өөрийн хүмүүсийг аюулгүй байдалд бэлтгэхдээ Бурханы зарлигуудыг дагасны учир болой.

28 Мөнхүү улиран тохиох дор, нөгөөтэйгүүр, Нифайн хүмүүс Их Эзэн Бурхандаа, тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлсөн түүний зүйрлэшгүй хүчний учир талархал илэрхийлэв.

29 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын арван ес дэх он төгсөв.

30 Тийм ээ, мөн тэдний дунд үргэлжийн амгалан байв, мөн Хиламан, мөн Шиблон, мөн Кориантон, бас Аммон болон түүний ах дүүсээр, тийм ээ, мөн Бурханы ариун жаягаар томилогдсон, наманчлалд хүргэн баптисм хүртэж, мөн номлохоор хүмүүсийн дунд илгээгдсэн тэд бүгдээр тэдэнд тунхаглагдсан Бурханы үгэнд хандах тэдний анхаарал мөн хичээнгүй байдлын учир сүмд үлэмж агуу дэгжилт байв.

Thus the Nephites had all power over their enemies; and thus the Lamanites did attempt to destroy the Nephites until their chief captains were all slain; yea, and more than a thousand of the Lamanites were slain; while, on the other hand, there was not a single soul of the Nephites which was slain.

There were about fifty who were wounded, who had been exposed to the arrows of the Lamanites through the pass, but they were shielded by their shields, and their breastplates, and their head-plates, insomuch that their wounds were upon their legs, many of which were very severe.

And it came to pass, that when the Lamanites saw that their chief captains were all slain they fled into the wilderness. And it came to pass that they returned to the land of Nephi, to inform their king, Amalickiah, who was a Nephite by birth, concerning their great loss.

And it came to pass that he was exceedingly angry with his people, because he had not obtained his desire over the Nephites; he had not subjected them to the yoke of bondage.

Yea, he was exceedingly wroth, and he did curse God, and also Moroni, swearing with an oath that he would drink his blood; and this because Moroni had kept the commandments of God in preparing for the safety of his people.

And it came to pass, that on the other hand, the people of Nephi did thank the Lord their God, because of his matchless power in delivering them from the hands of their enemies.

And thus ended the nineteenth year of the reign of the judges over the people of Nephi.

Yea, and there was continual peace among them, and exceedingly great prosperity in the church because of their heed and diligence which they gave unto the word of God, which was declared unto them by Helaman, and Shiblon, and Corianton, and Ammon and his brethren, yea, and by all those who had been ordained by the holy order of God, being baptized unto repentance, and sent forth to preach among the people.

## Алма 50

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай дайны, эсвээс леменчүүдээс өөрийн хүмүүсийг өмгөөлөхөөр бэлтгэлүүдийг хийхээ зогссонгүй; учир нь, шүүгчдийн засаглалын хорьдугаар оны эхэнд тэрээр өөрийнх нь их цэрэг, Нифайчуудаар эзэмшигдэж асан тэр бүх нутаг даяар, бүх хотуудыг хүрээлүүлэн тэд шороон далангууд ухаж эхлэх болгов.
- 2 Мөн эдгээр шороон далан дээгүүр нь гуалингууд байв, тийм ээ, хотуудыг хүрээлүүлэн, хүнийхтэй адил өндөртэй гуалин тулгууруудыг босгох болгов.
- 3 Мөн тэрээр тэдгээр тулгууруудын оройгоор үзүүрт шонгуудыг хүрээлэн байрлуулах болгов; мөн тэдгээр нь бат бэх бөгөөд өндөр байв.
- 4 Мөн тэр тэдгээр шонгуудын дээрээс ажиглах цамхгуудыг баригдах болгож, мөн леменчүүдийн чулуу мөн сумнууд тэднийг гэмтээж чадахгүйн тулд тэрээр хориглох байруудыг тэдгээр цамхгууд дээр баруулах болгов.
- 5 Мөн тэдгээр нь тэд өөрсдийн хүслийн мөн өөрсдийн хүчний дагуу дээрээс нь чулуу хаяж, мөн хотын хананы дэргэд ойртохоор завдсан түүнийг алж болохуйцаар бэлтгэгдсэн байв.
- 6 Тийн бүх нутгийн хот болгоныг хүрээлүүлэн, дайснуудынхаа халдлагын эсрэг хориглолтуудыг Моронай бэлтгэсэн байлаа.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Моронай их цэргээ дорнодын аглаг буйд тийш одох болгов; тийм ээ, мөн тэд явж мөн дорнодын аглаг буйдад байсан бүх леменчүүдийг, Зарахемла нутгийн өмнөд дэх өөрсдийнх нь нутагт хөөв.
- 8 Мөн Нифайн нутаг дорнодын тэнгисээс өрнөдийг хүртэл чигээрээ шулуун үргэлжилж байв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор Моронай бүх леменчүүдийг өөрсдийнх нь эзэмшил нутгуудын умардахь, дорнод аглаг буйдаас зайлуулсны дараа, тэрээр Зарахемла нутаг дахь мөн эргэн тойрных нь нутгийн оршин суугчдыг дорнын аглаг буйд тийш бүр тэнгисийн эргийг хүртэл явуулж, мөн уг нутгийг эзэмших болгов.

## Alma 50

And now it came to pass that Moroni did not stop making preparations for war, or to defend his people against the Lamanites; for he caused that his armies should commence in the commencement of the twentieth year of the reign of the judges, that they should commence in digging up heaps of earth round about all the cities, throughout all the land which was possessed by the Nephites.

And upon the top of these ridges of earth he caused that there should be timbers, yea, works of timbers built up to the height of a man, round about the cities.

And he caused that upon those works of timbers there should be a frame of pickets built upon the timbers round about; and they were strong and high.

And he caused towers to be erected that overlooked those works of pickets, and he caused places of security to be built upon those towers, that the stones and the arrows of the Lamanites could not hurt them.

And they were prepared that they could cast stones from the top thereof, according to their pleasure and their strength, and slay him who should attempt to approach near the walls of the city.

Thus Moroni did prepare strongholds against the coming of their enemies, round about every city in all the land.

And it came to pass that Moroni caused that his armies should go forth into the east wilderness; yea, and they went forth and drove all the Lamanites who were in the east wilderness into their own lands, which were south of the land of Zarahemla.

And the land of Nephi did run in a straight course from the east sea to the west.

And it came to pass that when Moroni had driven all the Lamanites out of the east wilderness, which was north of the lands of their own possessions, he caused that the inhabitants who were in the land of Zarahemla and in the land round about should go forth into the east wilderness, even to the borders by the seashore, and possess the land.

- 10 Мөн түүнчлэн тэрээр өөрсдийн эзэмшлүүдийн хил дээр өмнөдөд их цэргийг байрлуулж, мөн их цэрэг мөн ард түмнээ дайснуудынхаа гараас хамгаалж болохын тулд бэхлэлт босгох болгов.
- 11 Мөн тийн тэрээр леменчүүдийн дорнын аглаг буйдад, тийм ээ, мөн түүнчлэн өрнөдөд байх тэр бүх бэхлэлтийг тусгаарлаж, нифайчууд мөн леменчүүдийн хооронд, Зарахемла нутаг мөн Нифайн нутгийн хооронд, өрнийн тэнгисээс Сидон голын эхийн дэргэдүүр орших хилийн бэхлэлтийг барив— нифайчууд умардын бүх нутгийг, тийм ээ, бүр Өгөөмөр нутгийн умардад байсан бүх нутгийг тааллынхаа дагуу эзэмшсэн бөлгөө.
- 12 Тийн Моронай, өөрийнх нь ажлын тэдэнд авчрах хамгаалалтын баталгаатайн учир өдөр бүр өсөн нэмэгдэх их цэрэгтэйгээ, тэд эзэмшлийн нутгууд дээр нь хүч нөлөөгүй байхын тулд леменчүүдийн хүч болоод чадлыг эзэмшлийнхээ нутгуудаас тусгаарлахыг эрэлхийлсэн аж.
- 13 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд нэгэн хотын суурийг эхлэв, мөн тэд хотын нэрийг Моронай хэмээв; мөн энэ нь дорнын тэнгисийн эрэгт байв; мөн энэ нь леменчүүдийн эзэмшлүүдийн хилийн шугамын ойролцоо өмнөдөд байлаа.
- 14 Мөн түүнчлэн тэд Моронай хот мөн Аарон хот хоёрын хооронд Аарон мөн Моронайн хилүүдийг нэгтгэн нэгэн хотын суурийг эхлэв; мөн тэд уг хотын, өөрөөр хэлбэл уг нутгийн нэрийг Нифайха хэмээв.
- 15 Мөн түүнчлэн тэд мөнхүү онд умардад олон хот, умардад тэнгисийн хөвөөнд байсан тэр, нэг хотыг нэгэн тодорхой маягаар барьж Лихай гэж тэд нэрлэв.
- 16 Мөн тийн хорьдугаар он төгсөв.
- 17 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин нэгдүгээр оны эхэнд Нифайн хүмүүс эдгээр хөгжингүй нөхцөлд байв.
- 18 Мөн тэд үлэмж дэгжин, мөн тэд үлэмж баян болов; тийм ээ, мөн тэд уг нутагт өнөржиж мөн хүчирхэг болов.

And he also placed armies on the south, in the borders of their possessions, and caused them to erect fortifications that they might secure their armies and their people from the hands of their enemies.

And thus he cut off all the strongholds of the Lamanites in the east wilderness, yea, and also on the west, fortifying the line between the Nephites and the Lamanites, between the land of Zarahemla and the land of Nephi, from the west sea, running by the head of the river Sidon—the Nephites possessing all the land northward, yea, even all the land which was northward of the land Bountiful, according to their pleasure.

Thus Moroni, with his armies, which did increase daily because of the assurance of protection which his works did bring forth unto them, did seek to cut off the strength and the power of the Lamanites from off the lands of their possessions, that they should have no power upon the lands of their possession.

And it came to pass that the Nephites began the foundation of a city, and they called the name of the city Moroni; and it was by the east sea; and it was on the south by the line of the possessions of the Lamanites.

And they also began a foundation for a city between the city of Moroni and the city of Aaron, joining the borders of Aaron and Moroni; and they called the name of the city, or the land, Nephihah.

And they also began in that same year to build many cities on the north, one in a particular manner which they called Lehi, which was in the north by the borders of the seashore.

And thus ended the twentieth year.

And in these prosperous circumstances were the people of Nephi in the commencement of the twenty and first year of the reign of the judges over the people of Nephi.

And they did prosper exceedingly, and they became exceedingly rich; yea, and they did multiply and wax strong in the land.

- 19 Мөн хүмүүний үрсэд өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлэхдээ Их Эзэний бүх хэргүүд хичнээн нигүүлсэнгүй хийгээд шударга болохыг бид тийн харлаа; тийм ээ, Лихайд түүний ярьсан үгс батлагдсаныг бүр энэ цагт бид болгоож чадна, өгүүлсэн нь:
- 20 Чи болон чиний үрс адислагдсан болой; мөн тэд адислагдах болно, тэд миний зарлигуудыг дагахын хэрээр уг нутагт дэгжих болно. Гэвч санагтун, тэд миний зарлигуудыг дагахгүй байхын хэрээр тэд Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах болно.
- 21 Мөн эдгээр амлалтууд Нифайн хүмүүст батлагдсаар байсныг бид харав; учир нь тэдний дээрх өөрсдийнх нь дайнууд хийгээд устгалуудыг авчирсан нь тэдний дунд байсан тэрхүү хэрүүлүүд мөн зөрчлүүд, тийм ээ, тэдний аллагууд, мөн тэдний тонуулууд, тэд хуурамч шүтээнийг шүтдэг байсан нь, тэдний садар самуун, мөн жигшүүрт хэргүүд юм.
- 22 Мөн Их Эзэний зарлигуудыг дагахад итгэлтэй байсан тэд, өөрсдийнх нь мянга мянган ёс бус ах дүүс боолчлолд байхад, эсвээс илдэнд эрсдэхэд, эсвээс итгэлгүйдээ бууран доройтож, мөн леменчүүдтэй хутгалдсан үед цаг үргэлж чөлөөлөгдөж байв.
- 23 Гэвч болгоогтун Нифайн хүмүүсийн дунд, Нифайн өдрүүдээс, тийм ээ, энэ цаг үеэс хойш, шүүгчдийн засаглалын хориннэгдүгээр онд Моронайн өдрүүдээс илүү аз жаргалтай үе хэзээ ч байсангүй.
- 24 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин хоёрдугаар он; тийм ээ, мөн хорин гуравдугаар он ч түүнчлэн амар амгаланд төгсөв.
- 25 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин дөрөвдүгээр оны эхэнд ч, хэрэв тэдний дунд Лихайн хилтэй нийлсэн, хоёул тэнгисийн хөвөөнд байсан Лихайн нутгийн мөн Мориантоны нутгийн талаарх зөрчилдөөн байгаагүй сэн бол, Нифайн хүмүүсийн дунд түүнчлэн амар амгалан байх байв.
- 26 Учир нь болгоогтун, Мориантон нутгийг эзэмшсэн хүмүүс Лихай нутгийн хэсгийг нэхэмжлэв; тиймийн тул тэдний хооронд ширүүн зөрчилдөөн болж эхлэв, үүний хэрээр Мориантоны хүмүүс ах дүүсийнхээ эсрэг зэвсэг агсан, мөн тэднийг илдээр хөнөөхөөр тэд шийдэмгий байв.

And thus we see how merciful and just are all the dealings of the Lord, to the fulfilling of all his words unto the children of men; yea, we can behold that his words are verified, even at this time, which he spake unto Lehi, saying:

Blessed art thou and thy children; and they shall be blessed, inasmuch as they shall keep my commandments they shall prosper in the land. But remember, inasmuch as they will not keep my commandments they shall be cut off from the presence of the Lord.

And we see that these promises have been verified to the people of Nephi; for it has been their quarrelings and their contentions, yea, their murderings, and their plunderings, their idolatry, their whoredoms, and their abominations, which were among themselves, which brought upon them their wars and their destructions.

And those who were faithful in keeping the commandments of the Lord were delivered at all times, whilst thousands of their wicked brethren have been consigned to bondage, or to perish by the sword, or to dwindle in unbelief, and mingle with the Lamanites.

But behold there never was a happier time among the people of Nephi, since the days of Nephi, than in the days of Moroni, yea, even at this time, in the twenty and first year of the reign of the judges.

And it came to pass that the twenty and second year of the reign of the judges also ended in peace; yea, and also the twenty and third year.

And it came to pass that in the commencement of the twenty and fourth year of the reign of the judges, there would also have been peace among the people of Nephi had it not been for a contention which took place among them concerning the land of Lehi, and the land of Morianton, which joined upon the borders of Lehi; both of which were on the borders by the seashore.

For behold, the people who possessed the land of Morianton did claim a part of the land of Lehi; therefore there began to be a warm contention between them, insomuch that the people of Morianton took up arms against their brethren, and they were determined by the sword to slay them.

- 27 Гэвч болгоогтун, Лихай нутгийг эзэмшсэн хүмүүс Моронайн буудалд зугтан очиж, мөн түүнээс тусламж хүсэв; учир нь болгоогтун тэдний буруу биш байлаа.
- 28 Мөнхүү улиран тохиох дор Мориантон гэдэг хүнээр удирдуулж асан Мориантоны хүмүүс, Лихайн хүмүүс Моронайн буудалд зугтаж очсоныг олж мэдээд, тэд Моронайн их цэрэг өөрсөд дээр нь ирэн мөн өөрсдийг нь устгах вий хэмээн үлэмж айж байв.
- 29 Тиймийн тул Мориантон тэд их нуурууд олонтой, умард хэсгийн нутагт зугтан очиж, мөн умард хэсэгт байсан нутгийг эзэмшилдээ авна хэмээх бодлыг тэдний зүрх сэтгэлд төрүүлэв.
- 30 Мөн болгоогтун, тэд энэ төлөвлөгөөг ажил болгох бай, (харамслын шалтгаан болох байсан үүнийг) гэвч болгоогтун, Мориантон омог ихтэй хүн байсан учир, тиймийн тул тэрээр шивэгчингүүдийнхээ нэгэнд уурлаж, мөн тэр түүнийг дайрч мөн түүнийг ихэд зодов.
- 31 Мөнхүү улиран тохиох дор сайхь бүсгүй зугтаж, мөн Моронайн буудалд ирж, мөн Моронайд уг хэргийн талаар, мөн түүнчлэн умард нутагт зугтах гэсэн тэдний санааны талаар бүх зүйлийг Моронайд хэлэв.
- 32 Эдүгээ болгоогтун, тэд Мориантоны үгсийг дуулж мөн түүний хүмүүстэй нэгдэж, мөн тийн тэрээр уг нутгийн тэдгээр хэсгүүдийг эзэмшилдээ авах вий хэмээн Өгөөмөр нутагт байсан хүмүүс, чухамдаа бол Моронай айж байлаа, тэгвээс Нифайн хүмүүсийн дундах их уршгийн, тийм ээ, тэдний эрх чөлөөг унагахад хүргэх уршгийн суурь тавигдах байсан бөлгөө.
- 33 Тиймийн тул Моронай их цэргийг, буудлынх нь хамт, тэд умард нутаг тийш зугтахыг зогсоохоор Мориантоны хүмүүсийг амдуулахаар илгээв.
- 34 Мөнхүү улиран тохиох дор тэднийг Эзгүйрлийн нутгийн хилд ирэх хүртэл тэд тэднийг гүйцсэнгүй; мөн тэд умард нутагт хүргэх, тийм ээ, тэнгисийн дэргэдүүр, дорнодод мөн өрнөдөд тэнгисийн дэргэдүүрх нарийн гарцын тэнд тэднийг амдсан ажээ.

But behold, the people who possessed the land of Lehi fled to the camp of Moroni, and appealed unto him for assistance; for behold they were not in the wrong.

And it came to pass that when the people of Morianton, who were led by a man whose name was Morianton, found that the people of Lehi had fled to the camp of Moroni, they were exceedingly fearful lest the army of Moroni should come upon them and destroy them.

Therefore, Morianton put it into their hearts that they should flee to the land which was northward, which was covered with large bodies of water, and take possession of the land which was northward.

And behold, they would have carried this plan into effect, (which would have been a cause to have been lamented) but behold, Morianton being a man of much passion, therefore he was angry with one of his maid servants, and he fell upon her and beat her much.

And it came to pass that she fled, and came over to the camp of Moroni, and told Moroni all things concerning the matter, and also concerning their intentions to flee into the land northward.

Now behold, the people who were in the land Bountiful, or rather Moroni, feared that they would hearken to the words of Morianton and unite with his people, and thus he would obtain possession of those parts of the land, which would lay a foundation for serious consequences among the people of Nephi, yea, which consequences would lead to the overthrow of their liberty.

Therefore Moroni sent an army, with their camp, to head the people of Morianton, to stop their flight into the land northward.

And it came to pass that they did not head them until they had come to the borders of the land Desolation; and there they did head them, by the narrow pass which led by the sea into the land northward, yea, by the sea, on the west and on the east.

35 Мөнхүү улиран тохиох дор Моронайгаар илгээгдсэн, Тианкам гэдэг нэртэй хүнээр удирдагдсан тэрхүү их цэрэг Мориантоны хүмүүстэй тулгарав; мөн Мориантоны хүмүүс маш их зөрүүд байв, (түүний ёс бус мөн түүний зусар үгсээр тэд өдөөгдсөн учир) ийнхүү тэдний дунд Тианкам Мориантоныг алж мөн их цэргийг нь ялж, мөн тэднийг хоригдлууд болгон баривчилж, мөн Моронайн буудалд эргэж ирсэн тэрхүү тулаан эхэлсэн бөлгөө. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин дөрөв дэх он тийн төгсөв.

36 Мөн Мориантоны хүмүүс тийн буцаан авчрагдав. Мөн тэд энхийг сахих гэрээ хиймэгц, тэд Мориантоны нутагт дахин суурьшуулагдаж, мөн Лихайн хүмүүс болон тэдний дунд эвлэрэх ёс гүйцэтгэгдэв; мөн тэд түүнчлэн нутагтаа дахин суурьшуулагдав.

37 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүст тэдний энх амгалан сэргээгдсэн тус онд, Бурханы өмнө төгс зөв шударгаар шүүлтийн суудлыг эзэлсэн тэр хоёр дахь ерөнхий шүүгч Нифайха нас барав.

38 Гэсэн хэдий ч, Алма болон түүний эцэг өвгөдөөр хамгийн ариун нандин хэмээн үнэлэгдсэн тэдгээр цэдгүүд мөн тэдгээр зүйлүүдийг эзэмшүүлэх Алмагийн хүслээс тэрээр татгалзсан ажээ; тиймийн тул Алма тэдгээрийг өөрийн хүү, Хиламаны дээр шилжүүлэв

39 Болгоогтун, улиран тохиох дор Нифайхагийн хүү эцгийнхээ оронд шүүлтийн суудлыг эзлэхээр томилогдов; тийм ээ, зөв шударгаар шүүх, мөн ард олны энх амгалан хийгээд эрх чөлөөг сахин хамгаалах, мөн Их Эзэн Бурханаа шүтэн бишрэх ариун нандин боломжийг нь тэдэнд олгох, тийм ээ, өөрийн бүх өдрүүдэд Бурханы зорилгыг дэмжиж, хадгалахаар, тэрчлэн ёс бусыг үйлдэгчдийг гэмт хэргүүдийнх нь дагуу шударга ёсонд авчрах тангараг өргөн мөн ариун ёслолыг үйлдэж тэрээр ерөнхий шүүгч бөгөөд ард олны дээрх захирагчаар томилогдов.

40 Эдүгээ болгоогтун, түүний нэр Пахоран байв. Мөн Пахоран эцгийнхээ суудлыг эзэлж, мөн Нифайн хүмүүсийн дээрх өөрийн засаглалыг хорин дөрөвдүгээр оны төгсгөлд эхлүүлэв.

And it came to pass that the army which was sent by Moroni, which was led by a man whose name was Teancum, did meet the people of Morianton; and so stubborn were the people of Morianton, (being inspired by his wickedness and his flattering words) that a battle commenced between them, in the which Teancum did slay Morianton and defeat his army, and took them prisoners, and returned to the camp of Moroni. And thus ended the twenty and fourth year of the reign of the judges over the people of Nephi.

And thus were the people of Morianton brought back. And upon their covenanting to keep the peace they were restored to the land of Morianton, and a union took place between them and the people of Lehi; and they were also restored to their lands.

And it came to pass that in the same year that the people of Nephi had peace restored unto them, that Nephiah, the second chief judge, died, having filled the judgment-seat with perfect uprightness before God.

Nevertheless, he had refused Alma to take possession of those records and those things which were esteemed by Alma and his fathers to be most sacred; therefore Alma had conferred them upon his son, Helaman.

Behold, it came to pass that the son of Nephiah was appointed to fill the judgment-seat, in the stead of his father; yea, he was appointed chief judge and governor over the people, with an oath and sacred ordinance to judge righteously, and to keep the peace and the freedom of the people, and to grant unto them their sacred privileges to worship the Lord their God, yea, to support and maintain the cause of God all his days, and to bring the wicked to justice according to their crime.

Now behold, his name was Pahoran. And Pahoran did fill the seat of his father, and did commence his reign in the end of the twenty and fourth year, over the people of Nephi.

## Алма 51

- 1 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин тав дахь оны эхэнд, тэд Лихайн хүмүүс мөн Мориантоны хүмүүсийн хооронд нутгийнх нь талаар амгаланг тогтоогоод, мөн хорин тав дахь он энх амгаланд эхэлсний дараа;
- 2 Гэсэн хэдий ч, тэд уг нутаг дахь нийт энх амгаланг удаан сахьсангүй, учир нь ерөнхий шүүгч Пахораны талаар хүмүүсийн дунд зөрчилдөөн байж эхлэв; учир нь болгоогтун, хуулийн цөөн тодорхой зүйлүүд өөрчлөгдөх ёстой хэмээн хүссэн хэсэг хүмүүс байв.
- 3 Гэвч болгоогтун, Пахоран хуулийг өөрчлөх бас өөрчлөгдөхыг ч зөвшөөрсөнгүй; тиймийн тул, тэрээр хуулийг өөрчлөх тухай өөрсдийн саналыг айлтгалтайгаа илгээсэн тэднийг сонссонгүй.
- 4 Тиймийн тул, хуулийг өөрчлүүлэх хүсэлтэй тэд түүнд уурлаж, мөн түүнийг уг нутаг даяарх ерөнхий шүүгч байхыг болиулахыг хүсэв; тиймийн тул уг хэргийн талаар халуухан тэмцэл өрнөв, гэвч цус урсгахад хүрсэнгүй.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Пахораныг шүүгчийн суудлаас унагаах хүсэлтэй байсан тэд хааныг хүсэгч хүмүүс хэмээн нэрлэгдсэн ажгуу, учир нь тэд чөлөөт засгийг түлхэн унагаж мөн уг нутаг даяар хааныг тогтоох байдлаар хууль өөрчлөгдөхийг хүсч байв.
- 6 Мөн Пахораныг уг нутгийн дээрх ерөнхий шүүгчээр үлдээхийг хүссэн тэд өөрсдийн дээр чөлөөт байдлыг хүсэгч хүмүүс хэмээх нэр авчээ; мөн тэдний дунд хагарал ийм байв, учир нь чөлөөт байдлыг хүсэгч хүмүүс өөрсдийн эрхүүд хийгээд өөрсдийн шашин шүтлэгийн боломжуудаа чөлөөт засгаар батлан хамгаалуулахаар тангараглаж өөрөөр хэлбэл гэрээлсэн байв.

## Alma 51

And now it came to pass in the commencement of the twenty and fifth year of the reign of the judges over the people of Nephi, they having established peace between the people of Lehi and the people of Morianton concerning their lands, and having commenced the twenty and fifth year in peace;

Nevertheless, they did not long maintain an entire peace in the land, for there began to be a contention among the people concerning the chief judge Pahoran; for behold, there were a part of the people who desired that a few particular points of the law should be altered.

But behold, Pahoran would not alter nor suffer the law to be altered; therefore, he did not hearken to those who had sent in their voices with their petitions concerning the altering of the law.

Therefore, those who were desirous that the law should be altered were angry with him, and desired that he should no longer be chief judge over the land; therefore there arose a warm dispute concerning the matter, but not unto bloodshed.

And it came to pass that those who were desirous that Pahoran should be dethroned from the judgment-seat were called king-men, for they were desirous that the law should be altered in a manner to overthrow the free government and to establish a king over the land.

And those who were desirous that Pahoran should remain chief judge over the land took upon them the name of freemen; and thus was the division among them, for the freemen had sworn or covenanted to maintain their rights and the privileges of their religion by a free government.

7 Мөнхүү улиран тохиох дор тэдний зөрчилдөөний энэхүү хэрэг хүмүүсийн саналаар таслагдсан ажээ. Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн санал чөлөөт байдлыг хүсэгч хүмүүсийн талд болж, мөн Пахоран шүүлтийн суудалд хэвээр үлдсэн нь Пахораны ах дүүс хийгээд түүнчлэн эрх чөлөөг хүсэгч хүмүүсийн оных нь дунд их баярыг авчирч, мөн тэд түүнчлэн хааныг хүсэгч хүмүүсийг дуугүй болгов, тиймээс тэд эсэргүүцэж зүрхэлсэнгүй харин эрх чөлөөний хөдөлгөөнийг хадгалан хамгаалахаас аргагүй болов.

8 Эдүгээ тэдгээр хаадыг таалагсад дээд зиндааныхан байв, мөн тэд хаад байхыг эрэлхийлэв; мөн хүмүүсийг захирах хүч чадал, эрх мэдлийг эрэлхийлэх тэднээр тэд дэмжигдэв.

9 Гэвч болгоогтун энэ нь Нифайн хүмүүсийн дунд тиймэрхүү зөрчилдөөн байхад аюултай үе байв; учир нь болгоогтун, нифайчуудын хүмүүсийн эсрэг, леменчүүдийн хүмүүсийн зүрх сэтгэлийг Амаликая дахин өдөөн хатгасан ажгуу, мөн тэрээр нутгийнхаа бүх хэсгээс цэргүүдийг нэгтгэн цуглуулж, мөн тэднийг зэвсэглэн, мөн дайнд байдгаараа хичээнгүйлэн бэлтгэж байв; учир нь тэр Моронайн цусыг уухаар ам алдсан бөлгөө.

10 Гэвч болгоогтун, бид түүний амлалт яаруу хийгдсэнийг харах болно; гэсэн хэдий ч, тэрбээр өөрийгөө мөн их цэргээ нифайчуудын эсрэг тулалдаанд орохоор бэлтгэжээ.

11 Эдүгээ түүний их цэрэг, нифайчуудын гараар алагдсан олон мянгын учир урьд байсан шигээ тийм агуу байсангүй; гэвч тэдний их хохирол байсан хэдий ч, Амаликая их цэргийг гайхалтай олноор нэгтгэн цуглуулсан байв, үүний хэрээр тэр Зарахемла нутаг уруу очихоос айсангүй.

12 Тийм ээ, бүр Амаликая өөрөө леменчүүдийн тэргүүнд уруудан ирэв. Мөн энэ нь шүүгчдийн засаглалын хорин тав дахь онд байв; мөн энэ нь тэд өөрсдийн ерөнхий шүүгч Пахораны талаарх зөрчилдөөний хэргийг шийдэж эхэлсэнтэй нэгэн үед тохиов.

And it came to pass that this matter of their contention was settled by the voice of the people. And it came to pass that the voice of the people came in favor of the freemen, and Pahoran retained the judgment-seat, which caused much rejoicing among the brethren of Pahoran and also many of the people of liberty, who also put the king-men to silence, that they durst not oppose but were obliged to maintain the cause of freedom.

Now those who were in favor of kings were those of high birth, and they sought to be kings; and they were supported by those who sought power and authority over the people.

But behold, this was a critical time for such contentions to be among the people of Nephi; for behold, Amalickiah had again stirred up the hearts of the people of the Lamanites against the people of the Nephites, and he was gathering together soldiers from all parts of his land, and arming them, and preparing for war with all diligence; for he had sworn to drink the blood of Moroni.

But behold, we shall see that his promise which he made was rash; nevertheless, he did prepare himself and his armies to come to battle against the Nephites.

Now his armies were not so great as they had hitherto been, because of the many thousands who had been slain by the hand of the Nephites; but notwithstanding their great loss, Amalickiah had gathered together a wonderfully great army, insomuch that he feared not to come down to the land of Zarahemla.

Yea, even Amalickiah did himself come down, at the head of the Lamanites. And it was in the twenty and fifth year of the reign of the judges; and it was at the same time that they had begun to settle the affairs of their contentions concerning the chief judge, Pahoran.



- 13 Мөнхүү улиран тохиох дор хааныг хүсэгч хүмүүс гэж нэрлэгдсэн тэдгээр хүмүүс леменчүүд тэдний эсрэг тулалдахаар ирж явааг сонсоод, тэд зүрх сэтгэлдээ баяртай байв; мөн зэвсэг барихаас татгалзав, учир нь тэд ерөнхий шүүгчид, мөн түүнчлэн эрх чөлөөний хүмүүст, тэд улс орноо өмгөөлөхөөр зэвсэг барихааргүй тийм ихээр хилэгнэсэн байв.
- 14 Мөнхүү улиран тохиох дор Моронай үүнийг хараад, мөн түүнчлэн леменчүүд нутгийн хилд орж буйг хараад, хамгаалж үлдэхийн тулд тийм ихээр хөдөлмөрлөсөн тэдгээр хүмүүсийнхээ зөрүүдийн учир тэрээр үлэмж хилэгнэж байв; тийм ээ, тэрээр үлэмж хилэгнэж байв, түүний бодгаль тэдний эсрэг уурандаа багтарч байв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэр түүнээс үүнийг уншихыг, мөн тэдгээр тэрслэгчдийг улс орноо өмгөөлөхийг албадан эс бөгөөс үхэлд хүргэх мэдэл хүчийг өөрт нь (Моронайд) өгөхийг хүсэн, хүмүүсийн саналыг тээсэн айлтгалыг уг нутгийн эрх баригчид илгээв.
- 16 Учир нь хүмүүсийн дундах зөрчилдөөнүүд хийгээд тэрслэлүүдийг төгсгөх нь түүний анхны ажил байв; учир нь болгоогтун, энэ нь одоо хүртэл тэдний бүх устгалын шалтгаан байлаа. Мөнхүү улиран тохиох дор энэ нь хүмүүсийн саналын дагуу зөвшөөрөгдөв.
- 17 Мөнхүү улиран тохиох дор, хааныг хүсэгч хүмүүсийн эсрэг явж, тэдний бардамналыг мөн сурвалжит байдлыг унаган мөн тэднийг газартай тэгшлэх, эсвээс тэд зэвсэг барьж мөн эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжихийг албадахыг Моронай их цэрэгтээ зарлиглав.
- 18 Мөнхүү улиран тохиох дор их цэрэг тэдний эсрэг давшин оржээ; мөн тэдний бардамналыг хийгээд сурвалжит байдлыг унагаж, үүний хэрээр тэд Моронайн хүмүүсийн эсрэг тулалдахаар дайны зэр зэвсгээ өргөмөгц тэд хиаран унаж, газартай тэгшлэгдсэн байв.
- 19 Мөнхүү улиран тохиох дор тэдгээр тэрслэгсдээс илдээр хиар цохиулсан нь дөрвөн мянга байв; мөн тэдний удирдагчдаас тулалдаанд алагдаагүй нь баривчлагдаж мөн шоронд хаягдав, учир нь энэ үед тэдний шүүлтэд зориулах цаг байсангүй.

And it came to pass that when the men who were called king-men had heard that the Lamanites were coming down to battle against them, they were glad in their hearts; and they refused to take up arms, for they were so wroth with the chief judge, and also with the people of liberty, that they would not take up arms to defend their country.

And it came to pass that when Moroni saw this, and also saw that the Lamanites were coming into the borders of the land, he was exceedingly wroth because of the stubbornness of those people whom he had labored with so much diligence to preserve; yea, he was exceedingly wroth; his soul was filled with anger against them.

And it came to pass that he sent a petition, with the voice of the people, unto the governor of the land, desiring that he should read it, and give him (Moroni) power to compel those dissenters to defend their country or to put them to death.

For it was his first care to put an end to such contentions and dissensions among the people; for behold, this had been hitherto a cause of all their destruction. And it came to pass that it was granted according to the voice of the people.

And it came to pass that Moroni commanded that his army should go against those king-men, to pull down their pride and their nobility and level them with the earth, or they should take up arms and support the cause of liberty.

And it came to pass that the armies did march forth against them; and they did pull down their pride and their nobility, insomuch that as they did lift their weapons of war to fight against the men of Moroni they were hewn down and leveled to the earth.

And it came to pass that there were four thousand of those dissenters who were hewn down by the sword; and those of their leaders who were not slain in battle were taken and cast into prison, for there was no time for their trials at this period.

20 Мөн тэдгээр тэрслэгсдийн үлдсэн нь, илдээр доош газар цохигдохын оронд, эрх чөлөөний туган дор бууж өгөөд, мөн эрх чөлөөний далбааг цамхгууд дээрээ мөн хотууддаа өргөхөөр, мөн улс орноо өмгөөлөхийн төлөө зэвсэг агсахаар албадуулагдав.

21 Мөн тийн Моронай хааныг хүсэгч хүмүүсийн төгсгөлийг тавьж, тиймээс хааныг хүсэгч хэмээх нэрээр нэрлэгдэх хэн ч үгүй болов; мөн тийн тэрээр сурвалжит цустай хэмээсэн тэдгээр хүмүүсийн зөрүүд хийгээд бардам занг төгсгөл болгов; харин тэд ах дүүсийнхээ адил өөрсдийгөө доош даруусгаж, мөн боолчлолоос эрх чөлөөтэй байхын тулд эрэлхэг зоригтойгоор тулалдахад албадуулагдав.

22 Болгоогтун, улиран тохиох дор Моронай тийн өөрийнхөө хүмүүсийн дундах дайнууд хийгээд зөрчилдөөнүүдийг зогсоож, мөн тэднийг амар амгалан болон соёл иргэншилд харьяалуулж, мөн леменчүүдийн эсрэг дайнд бэлтгэхээр журмуудыг бий болгож байх зуур, болгоогтун, леменчүүд тэнгисийн эргээр хиллэдэг байсан Моронайн нутагт орж ирсэн байв.

23 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд Моронай хотод хангалттай хүчирхэг байсангүй; тиймийн тул Амаликая олныг алснаар тэднийг хөөв. Мөнхүү улиран тохиох дор Амаликая хотын эзэмшлийг, тийм ээ, тэдний бүх бэхлэлт хамгаалалтын эзэмшлийг авчээ.

24 Мөн Моронай хотоос гарч зугтсан тэд Нифайха хотод ирэв; мөн түүнчлэн Лихай хотын хүмүүс нэгдэн цугларцгааж, мөн бэлтгэлийг базаан тэгээд леменчүүдийг тулалдаанд хүлээн авахад бэлэн болов.

25 Гэвч улиран тохиох дор Амаликая Нифайха хотын эсрэг тулалдахаар леменчүүдийг явахыг зөвшөөрсөнгүй, харин тэднийг тэнгисийн эрэгт байлгаж, хот болгонд сахиж мөн өмгөөлүүлэхээр эрчүүдийг үлдээж байв.

26 Мөн тийн тэрээр одож, олон хот, Нифайха хотыг, мөн Лихай хот, мөн Мориантон хот, мөн Омнер хот, мөн Гид хот, мөн Мюлек хотыг, тэнгисийн эрэгт, дорнодод байсан бүгдийг эзэмшилдээ авсаар цаашлав.

And the remainder of those dissenters, rather than be smitten down to the earth by the sword, yielded to the standard of liberty, and were compelled to hoist the title of liberty upon their towers, and in their cities, and to take up arms in defence of their country.

And thus Moroni put an end to those king-men, that there were not any known by the appellation of king-men; and thus he put an end to the stubbornness and the pride of those people who professed the blood of nobility; but they were brought down to humble themselves like unto their brethren, and to fight valiantly for their freedom from bondage.

Behold, it came to pass that while Moroni was thus breaking down the wars and contentions among his own people, and subjecting them to peace and civilization, and making regulations to prepare for war against the Lamanites, behold, the Lamanites had come into the land of Moroni, which was in the borders by the seashore.

And it came to pass that the Nephites were not sufficiently strong in the city of Moroni; therefore Amalickiah did drive them, slaying many. And it came to pass that Amalickiah took possession of the city, yea, possession of all their fortifications.

And those who fled out of the city of Moroni came to the city of Nephihah; and also the people of the city of Lehi gathered themselves together, and made preparations and were ready to receive the Lamanites to battle.

But it came to pass that Amalickiah would not suffer the Lamanites to go against the city of Nephihah to battle, but kept them down by the seashore, leaving men in every city to maintain and defend it.

And thus he went on, taking possession of many cities, the city of Nephihah, and the city of Lehi, and the city of Morianton, and the city of Omner, and the city of Gid, and the city of Mulek, all of which were on the east borders by the seashore.

- 27 Мөн тийн леменчүүд Амаликаягийн башир аргаар, ийм тоо томшгүй ийм олон цэргээрээ олон хотыг эзэлж авав, тэр бүгд нь Моронайн бэхлэлтүүдийн маягаар бат бэхээр бэхлэгдсэн байв; тэр бүгд леменчүүдэд хориглолт болов.
- 28 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчуудыг өмнөө тууж мөн олныг нь алсаар Өгөөмөр нутгийн хилд жагсан очив.
- 29 Гэвч улиран тохиох дор Морриантоныг алж мөн түүний хүмүүсийг зугтаж байхад нь амдсан Тианкамтай тэд тулгарав.
- 30 Мөнхүү улиран тохиох дор тэрээр, олон тооны их цэрэгтэйгээ хамт Өгөөмөр нутгийг, мөн түүнчлэн умард нутгийг эзэмшилдээ авч болно хэмээн жагсаж явахад нь түүнчлэн Амаликаяг амдав.
- 31 Гэвч болгоогтун тэрээр Тианкам болон түүний хүмүүсээр буцаагдсанаар амжилтанд хүрсэнгүй, учир нь тэд агуу дайчид байв; учир нь Тианкамын хүн бүр нь леменчүүдээс хүч чадал хийгээд дайтах чадвараараа давуу байв, үүний хэрээр тэд леменчүүдийг давамгайлсан бөлгөө.
- 32 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг зовоож, үүний хэрээр тэд тэднийг бүр харанхуй болтол алав. Мөнхүү улиран тохиох дор Тианкам болон түүний хүмүүс Өгөөмөр нутгийн хилийн тэнд майхнуудаа босгов; мөн Амаликая майхнуудаа тэнгисийн эргийн дэвсгэ дээрх хилийн тэнд босгож, мөн энэ маягаар тэд туугдсан ажээ.
- 33 Мөнхүү улиран тохиох дор шөнө ирэхэд, Тианкам болон түүний зарц сэмхэн гарч мөн шөнөөр явж, бас Амаликаягийн буудалд очив; мөн болгоогтун, тэд өдрийн хөдөлмөр бас халуунаас болж машид ядарснаас тэд нойрондоо дийлдсэн байв.
- 34 Мөнхүү улиран тохиох дор Тианкам нууцаар хааны майханд сэмхэн орж, мөн зүрхэнд нь жад зоов; мөн тэрээр тэр даруй хааныг үхүүлсэн учир, тэрээр зарц нарыг нь сэрээсэнгүй.
- 35 Мөн тэрээр буудалдаа нууцаар буцаж ирэхэд, мөн болгоогтун, хүмүүс нь унтаж байв, мөн тэрбээр тэднийг сэрээж мөн хийсэн бүх зүйлээ тэдэнд хэлэв.

And thus had the Lamanites obtained, by the cunning of Amalickiah, so many cities, by their numberless hosts, all of which were strongly fortified after the manner of the fortifications of Moroni; all of which afforded strongholds for the Lamanites.

And it came to pass that they marched to the borders of the land Bountiful, driving the Nephites before them and slaying many.

But it came to pass that they were met by Teancum, who had slain Morianton and had headed his people in his flight.

And it came to pass that he headed Amalickiah also, as he was marching forth with his numerous army that he might take possession of the land Bountiful, and also the land northward.

But behold he met with a disappointment by being repulsed by Teancum and his men, for they were great warriors; for every man of Teancum did exceed the Lamanites in their strength and in their skill of war, inasmuch that they did gain advantage over the Lamanites.

And it came to pass that they did harass them, inasmuch that they did slay them even until it was dark. And it came to pass that Teancum and his men did pitch their tents in the borders of the land Bountiful; and Amalickiah did pitch his tents in the borders on the beach by the seashore, and after this manner were they driven.

And it came to pass that when the night had come, Teancum and his servant stole forth and went out by night, and went into the camp of Amalickiah; and behold, sleep had overpowered them because of their much fatigue, which was caused by the labors and heat of the day.

And it came to pass that Teancum stole privily into the tent of the king, and put a javelin to his heart; and he did cause the death of the king immediately that he did not awake his servants.

And he returned again privily to his own camp, and behold, his men were asleep, and he awoke them and told them all the things that he had done.

36 Мөн тэрбээр леменчүүд сэрж мөн тэдний зүг  
ирэхвий хэмээн их цэргээ бэлэн байлдалд оруулав.

37 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн  
засаглалын хорин тавдугаар он төгсөв; мөн тийн  
Амаликаягийн өдрүүд төгсөв.

And he caused that his armies should stand in readi-  
ness, lest the Lamanites had awakened and should come  
upon them.

And thus endeth the twenty and fifth year of the  
reign of the judges over the people of Nephi; and thus  
endeth the days of Amalickiah.

## Алма 52

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин зургадугаар онд, болгоогтун, эхний сарын эхний өдөр леменчүүд сэргээд, болгоогтун, Амаликая майхандаа үхсэнийг олов; мөн түүнчлэн тэд Тианкам тэр өдөртөө тэднийг дайлаар мордоход бэлэн буйг тэд үзэв.
- 2 Мөн эдүгээ, леменчүүд үүнийг үзээд айв; мөн тэд уг нутгийн умард тийш жагсан очих тухай бодлоо орхиж, мөн бүх их цэрэгтэйгээ Мюлек хотод ухарч, мөн бэхлэлтэндээ хамгааллыг эрэлхийлэв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор Амаликаягийн дүү уг хүмүүсийн дээр хаанаар тохоогдов; мөн түүний нэр Амморон байв; тийн хаан Амморон, Амаликая хааны дүү, түүний оронд засаглахаар тохоогдов.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүс цус урсгаснаар авсан хотуудаа хамгаалан хадгалахыг зарлиглав; учир нь тэд их цус алдалгүйгээр тэд ямар ч хотыг аваагүй билээ.
- 5 Мөн эдүгээ, леменчүүд өөрсдийн авсан хотуудыг мөн эзэмшилдээ олж авсан уг нутгийн тэдгээр хэсгүүдийг хадгалан хамгаалахаар шийдсэнийг Тианкам харав; мөн түүнчлэн тэдний тооны асар олныг хараад, Тианкам бэхлэлтүүдэд нь тэднийг довтолхыг оролдох нь зүйд нийцэхгүй хэмээн боджээ.
- 6 Гэвч тэрээр өөрийн хүмүүсийг эргэн тойронд нь, дайны тулд бэлтгэлүүдийг базааж буй мэтээр байлгаж байв; тийм ээ, мөн үнэндээ тэрээр хүрээлэн байх хэрмүүдийг босгож мөн хориглох байруудыг бэлтгэснээр өөрийгөө тэднээс хамгаалахаар бэлтгэж байв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Моронай олон тооны хүмүүсийг их цэргийг нь хүчирхэгжүүлэхээр илгээх хүртэл тэрээр тийн дайнд бэлтгэж байв.
- 8 Мөн түүнчлэн, тэрбээр гарт нь орсон бүх олзлогдосдыг хадгалах ёстой хэмээх тушаалуудыг Моронай түүнд илгээв; учир нь леменчүүд олныг олзлон авсны хэрээр, тэрбээр леменчүүдэд олзлогдсон тэдний золиосонд леменчүүдээс олзлогдсон бүгдийг хадгалах ёстой хэмээсэн ажгуу.

## Alma 52

And now, it came to pass in the twenty and sixth year of the reign of the judges over the people of Nephi, behold, when the Lamanites awoke on the first morning of the first month, behold, they found Amalickiah was dead in his own tent; and they also saw that Teancum was ready to give them battle on that day.

And now, when the Lamanites saw this they were affrighted; and they abandoned their design in marching into the land northward, and retreated with all their army into the city of Mulek, and sought protection in their fortifications.

And it came to pass that the brother of Amalickiah was appointed king over the people; and his name was Ammoron; thus king Ammoron, the brother of king Amalickiah, was appointed to reign in his stead.

And it came to pass that he did command that his people should maintain those cities, which they had taken by the shedding of blood; for they had not taken any cities save they had lost much blood.

And now, Teancum saw that the Lamanites were determined to maintain those cities which they had taken, and those parts of the land which they had obtained possession of; and also seeing the enormity of their number, Teancum thought it was not expedient that he should attempt to attack them in their forts.

But he kept his men round about, as if making preparations for war; yea, and truly he was preparing to defend himself against them, by casting up walls round about and preparing places of resort.

And it came to pass that he kept thus preparing for war until Moroni had sent a large number of men to strengthen his army.

And Moroni also sent orders unto him that he should retain all the prisoners who fell into his hands; for as the Lamanites had taken many prisoners, that he should retain all the prisoners of the Lamanites as a ransom for those whom the Lamanites had taken.

- 9 Мөн леменчүүд уг газрыг эзэлж аваад тал бүрээс нь зовоох хүчийг олох вий хэмээн тэрээр түүнчлэн Өгөөмөр нутгийг бэхэлж, мөн умард нутаг тийш удирддаг нарийн гарцыг хамгаалах ёстой хэмээх тушаалуудыг илгээжээ.
- 10 Мөн түүнчлэн тэрээр нутгийн уг хэсгийг хадгалан хамгаалахдаа итгэлтэй байж, мөн тэрээр гараас нь булаагдсан тэдгээр хотуудыг заль мэхээр эсвээс ямар нэгэн өөр аргаар буцаан авч магадын тулд, уг хэсэгт леменчүүдийг цээрлүүлэх өөрийн хүч хүрэх боломж бүрийг эрэлхийлэхийг; мөн тэрбээр түүнчлэн леменчүүдийн гарт ороогүй байгаа тэдгээр эргэн тойрныхоо хотуудыг бэхлэн, хүчирхэгжүүлэхийг хүсэн Моронай түүнд илгээжээ.
- 11 Мөн тэрбээр түүнчлэн түүнд хэлэв, би чам дээр очмоор байна, гэвч болгоогтун, леменчүүд өрнийн тэнгисийн тэнд нутгийн хилд бидний дээр ирлээ; мөн болгоогтун, би тэдний эсрэг явна, тиймийн тул би чам дээр очиж чадахгүй нь.
- 12 Эдүгээ хаан (Амморон) Зарахемла нутгаас гарч одоод, мөн ахынхаа үхлийн талаар хатанд мэдүүлж, мөн маш олон тооны эрсийг нэгтгэн цуглуулж, нифайчуудын эсрэг өрнөд тэнгисийн дэргэдэх хил дээр давшин очсон байв.
- 13 Мөн тийн тэрээр нифайчуудыг зовоохыг, мөн тэдний хүчний нэг хэсгийг нутгийн уг хэсэг тийш дагуулахыг хичээж байв, тэгэхдээ түүнчлэн тэд ч нифайчуудыг дорнод тэнгисийн дэргэдэх хил дээр зовоохыг, мөн их цэргийнхээ хүчний дагуу хүч хүрэхийнхээ хэрээр нутгуудыг нь эзэмшилдээ авахыг тэрээр эзэлсэн хотуудаа захируулахаар үлдээсэн хүмүүстээ зарлиглажээ.
- 14 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин зургадугаар оны төгсгөлд, тийн нифайчууд тэдгээр аюултай нөхцөлд байв.
- 15 Гэвч болгоогтун, улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин долдугаар онд, Тианкам, Моронайн тушаалаар—нутгийн өмнөд болон өрнөд хилийг хамгаалах их цэргийг байгуулж, мөн алдсан хотуудаа буцаан авахад Тианкамыг тэрээр өөрийн хүмүүсээр дэмжиж болохын тулд Өгөөмөр нутгийн зүг жагсан явж эхэлсэн буюу—

And he also sent orders unto him that he should fortify the land Bountiful, and secure the narrow pass which led into the land northward, lest the Lamanites should obtain that point and should have power to harass them on every side.

And Moroni also sent unto him, desiring him that he would be faithful in maintaining that quarter of the land, and that he would seek every opportunity to scourge the Lamanites in that quarter, as much as was in his power, that perhaps he might take again by stratagem or some other way those cities which had been taken out of their hands; and that he also would fortify and strengthen the cities round about, which had not fallen into the hands of the Lamanites.

And he also said unto him, I would come unto you, but behold, the Lamanites are upon us in the borders of the land by the west sea; and behold, I go against them, therefore I cannot come unto you.

Now, the king (Ammoron) had departed out of the land of Zarahemla, and had made known unto the queen concerning the death of his brother, and had gathered together a large number of men, and had marched forth against the Nephites on the borders by the west sea.

And thus he was endeavoring to harass the Nephites, and to draw away a part of their forces to that part of the land, while he had commanded those whom he had left to possess the cities which he had taken, that they should also harass the Nephites on the borders by the east sea, and should take possession of their lands as much as it was in their power, according to the power of their armies.

And thus were the Nephites in those dangerous circumstances in the ending of the twenty and sixth year of the reign of the judges over the people of Nephi.

But behold, it came to pass in the twenty and seventh year of the reign of the judges, that Teancum, by the command of Moroni—who had established armies to protect the south and the west borders of the land, and had begun his march towards the land Bountiful, that he might assist Teancum with his men in retaking the cities which they had lost—

16 Мөнхүү улиран тохиох дор Тианкам Мюлек хотод дайралт хийж, мөн хэрэв энэ нь боломжтой байваас үүнийг буцаан авах тушаал хүлээн авчээ.

17 Мөнхүү улиран тохиох дор Тианкам Мюлек хотод дайралт хийх, мөн их цэргийнхээ хамт леменчүүдийн эсрэг давшин очих бэлтгэлүүдийг базаав; гэвч тэднийг бэхлэлтэндээ байхад нь дийлэх боломжгүйг тэр ойлгов; тиймийн тул тэрээр төлөвлөгөөгөө орхиж мөн Өгөөмөр хотод, тэрээр их цэрэгтээ хүч нэмж болно хэмээн, Моронайн ирэлтийг хүлээхээр буцаж ирэв.

18 Мөнхүү улиран тохиох дор Моронай их цэргийнхээ хамт Өгөөмөр нутагт, Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин долдугаар оны эцэст хүрч ирэв.

19 Мөн хорин наймдугаар оны эхэнд—леменчүүдийг тэдний эсрэг тулалдахаар гарч ирэхэд хүргэхийн тулд; эсвээс тэд тэднээс давуу талыг олж мөн Мюлек хотыг дахин авч болно хэмээн тэднийг хориглолтоос нь ямар нэгэн аргаар залилж гаргахын тулд юу хийх ёстой талаар, Моронай болон Тианкам мөн ерөнхий ахмадуудаас олон нь дайны зөвлөлдөөн хийв.

20 Мөнхүү улиран тохиох дор Мюлек хотыг хамгаалж буй, леменчүүдийн их цэрэгт, нэрийг нь Иаков гэдэг байсан тэдний удирдагчид түүнийг цэргийнхээ хамт тэдэнтэй тулалдахаар уг хоёр хотын хоорондох талбай дээр гарч ирэхийг хүсэн элч нарыг тэд илгээв. Гэвч болгоогтун, Иаков, зорам үндэстэн байсан тэрээр, цэрэгтэйгээ талбай дээр тэдэнтэй тулалдахаар гарч ирсэнгүй.

21 Мөнхүү улиран тохиох дор Моронай, тэдэнтэй тэгш нөхцөлд байх газар тулалдах найдвар байсангүй, тиймийн тул, тэрээр леменчүүдийг хориглолтоос нь гаргахаар залилж болохын тулд төлөвлөгөөг зохиов.

22 Тиймийн тул тэрээр, Тианкамыг цөөн тооны эрсийг авч мөн тэнгисийн эргийн дэргэдүүр уруудан жагсаж явах болгов; мөн Моронай болон түүний их цэрэг, шөнөөр, аглаг буйдад, Мюлек хотын өрнөдөд жагсан очив; мөн ийн, маргааш нь, леменчүүдийн харуулууд Тианкамыг олж хараад, тэд гүйлдэж мөн үүнийг өөрсдийн удирдагч Иаковт хэлэв.

And it came to pass that Teancum had received orders to make an attack upon the city of Mulek, and retake it if it were possible.

And it came to pass that Teancum made preparations to make an attack upon the city of Mulek, and march forth with his army against the Lamanites; but he saw that it was impossible that he could overpower them while they were in their fortifications; therefore he abandoned his designs and returned again to the city Bountiful, to wait for the coming of Moroni, that he might receive strength to his army.

And it came to pass that Moroni did arrive with his army at the land of Bountiful, in the latter end of the twenty and seventh year of the reign of the judges over the people of Nephi.

And in the commencement of the twenty and eighth year, Moroni and Teancum and many of the chief captains held a council of war—what they should do to cause the Lamanites to come out against them to battle; or that they might by some means flatter them out of their strongholds, that they might gain advantage over them and take again the city of Mulek.

And it came to pass they sent embassies to the army of the Lamanites, which protected the city of Mulek, to their leader, whose name was Jacob, desiring him that he would come out with his armies to meet them upon the plains between the two cities. But behold, Jacob, who was a Zoramite, would not come out with his army to meet them upon the plains.

And it came to pass that Moroni, having no hopes of meeting them upon fair grounds, therefore, he resolved upon a plan that he might decoy the Lamanites out of their strongholds.

Therefore he caused that Teancum should take a small number of men and march down near the seashore; and Moroni and his army, by night, marched in the wilderness, on the west of the city Mulek; and thus, on the morrow, when the guards of the Lamanites had discovered Teancum, they ran and told it unto Jacob, their leader.

23 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг тэдний тоо цөөн учир Тианкамыг тоогоороо дийлнэ хэмээн сэтгэж, Тианкамын эсрэг давшин очив. Мөн Тианкам леменчүүдийн их цэрэг түүний эсрэг гарч ирж буйг хараад тэнгисийн эргээр умард зүг ухарч эхлэв.

24 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд түүний зугтаж эхлэхийг хараад, тэд зоригжин мөн идэвхтэйгээр мөрдөн хөөв. Мөн Тианкам ийн тэднийг хоосон мөрдөж буй леменчүүдийг зайлуулан дагуулж байх зуур, болгоогтун, Моронай өөргэй нь хамт байсан их цэргийнхээ нэг хэсгийг хотод давшин орохыг, мөн үүнийг эзэмшилдээ авахыг зарлиглав.

25 Мөн тэд тийн үйлдэж, мөн хотыг хамгаалахаар үлдээгдсэн тэд бүгдийг, тийм ээ, тэдний өмнө дайны зэвсгээ буулгаснаас бусад бүгдийг нь алжээ.

26 Мөн тийн Моронай их цэргийнхээ нэг хэсгээр Мюлек хотыг эзэмшилдээ авав, тэгэх зуураа тэрээр үлдсэн хэсэгтэй нь тэд Тианкамыг мөрдсөн мөрдөлтөөсөө эргэж ирэхэд нь леменчүүдтэй тулахаар давшин одов.

27 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Өгөөмөр хотын дэргэд очтолоо Тианкамыг мөрдөн хөөгөөд, мөн тэд Өгөөмөр хотыг хамгаалахаар үлдээгдсэн Лихай болон цөөн тооны их цэрэгтэй тулгарав.

28 Мөн эдүгээ болгоогтун, леменчүүдийн ерөнхий ахмад нь Лихай өөрийн цэрэгтэй тэдний эсрэг ирэхийг үзээд, тэд Мюлек хотод хүрэхээс нь өмнө Лихай тэднийг гүйцэх вий хэмээн тэд ихэд тэвдэн зугтав; учир нь тэд давшилтынхаа улмаас ядарсан байхад, харин Лихай эрс сэргэг байв.

29 Эдүгээ леменчүүд Моронай их цэрэгтэйгээ тэдний ард байсныг мэдсэнгүй; мөн тэдний айсан ганцхан юм нь Лихай болон түүний эрчүүд байв.

30 Эдүгээ Моронай болон түүний их цэрэгтэй тулгарах хүртэл нь Лихай тэднийг гүйцэх хүсэлгүй байлаа.

31 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд хол ухрахаасаа өмнө, нифайчуудаар, Моронайн эрсээр нэг талаасаа, мөн Лихайн хүмүүсээр, бүгд сэргэг хийгээд хүч чадал дүүрэн байсан тэднээр нөгөө талаасаа бүслэгдэв; харин леменчүүд урт удаан давшилтынхаа улмаас ядарсан байв.

And it came to pass that the armies of the Lamanites did march forth against Teancum, supposing by their numbers to overpower Teancum because of the smallness of his numbers. And as Teancum saw the armies of the Lamanites coming out against him he began to retreat down by the seashore, northward.

And it came to pass that when the Lamanites saw that he began to flee, they took courage and pursued them with vigor. And while Teancum was thus leading away the Lamanites who were pursuing them in vain, behold, Moroni commanded that a part of his army who were with him should march forth into the city, and take possession of it.

And thus they did, and slew all those who had been left to protect the city, yea, all those who would not yield up their weapons of war.

And thus Moroni had obtained possession of the city Mulek with a part of his army, while he marched with the remainder to meet the Lamanites when they should return from the pursuit of Teancum.

And it came to pass that the Lamanites did pursue Teancum until they came near the city Bountiful, and then they were met by Lehi and a small army, which had been left to protect the city Bountiful.

And now behold, when the chief captains of the Lamanites had beheld Lehi with his army coming against them, they fled in much confusion, lest perhaps they should not obtain the city Mulek before Lehi should overtake them; for they were wearied because of their march, and the men of Lehi were fresh.

Now the Lamanites did not know that Moroni had been in their rear with his army; and all they feared was Lehi and his men.

Now Lehi was not desirous to overtake them till they should meet Moroni and his army.

And it came to pass that before the Lamanites had retreated far they were surrounded by the Nephites, by the men of Moroni on one hand, and the men of Lehi on the other, all of whom were fresh and full of strength; but the Lamanites were wearied because of their long march.



- 32 Мөн тэд дайны зэвсгүүдээ хураалгах хүртэл тэдний зүг довтлохыг Моронай өөрийн хүмүүст зарлиг болгов.
- 33 Мөнхүү улиран тохиох дор зорам үндэстэн асан Иаков тэдний удирдагч нь, түүнчлэн, мөн дийлдэшгүй зоригтой байсан учир, тэрбээр Моронайн эсрэг тулалдахаар леменчүүдийг үлэмж омогтойгоор удирдав.
- 34 Моронай тэдний явах замд нь байсан учир, тиймийн тул Иаков тэднийг хөнөөж мөн Мюлек хотод хүрэх замаа гаргахаар шийдсэн байв. Гэвч болгоогтун, Моронай болон түүний эрс илүү хүчтэй байв; тиймийн тул тэд леменчүүдийн өмнө зам тавьж өгсөнгүй.
- 35 Мөнхүү улиран тохиох дор тэд аль аль талдаа үлэмж ширүүн тулалдав; мөн аль аль талд олон нь алагдав; тийм ээ, мөн Моронай шархдаж мөн Иаков алагдав.
- 36 Мөн арын хэсэгт явсан леменчүүд дайны зэвсгээ хураалгах болгосон тийм ширүүнээр тэднийг ар талаас Лихай хүчит эрчүүдтэйгээ шахав; мөн тэдний үлдсэн нь, ихэд балмагдсаны улмаас, хааш явах эсвэл хаашаа дайрахаа мэдэхгүй байв.
- 37 Эдүгээ Моронай тэдний балмагдсаныг хараад, тэр тэдэнд: Хэрэв та нар дайны зэвсгээ авчирч мөн тэдгээрийгээ хураалгавал, болгоогтун би та нарын цусыг урсгахаа болино хэмээв.
- 38 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд эдгээр угсийг сонсоод алагдаагүй байсан бүх ерөнхий ахмадууд ирж мөн Моронайн хөлд дайны зэвсгүүдээ доош хаяж, мөн түүнчлэн өөрсдийн эрсээ ч нэгэн адилаар үйлдэх ёстой хэмээн зарлиг болов.
- 39 Гэвч болгоогтун, тэгэхгүй нь олон байв; мөн илднүүдээ хураалгаагүй тэд баривчлагдаж мөн хүлэгдэж, мөн дайны зэвсгүүд нь тэднээс авагдав, мөн тэд ах дүүстэйгээ хамт Өгөөмөр нутаг тийш очихоор албадуулагдав.
- 40 Мөн эдүгээ баривчлагдсан олзлогдогсдын тоо алагдсан хүмүүсийн тооноос илүү, тийм ээ, аль аль талд нь алагдсан хүмүүсээс илүү гарчээ.

And Moroni commanded his men that they should fall upon them until they had given up their weapons of war.

And it came to pass that Jacob, being their leader, being also a Zoramite, and having an unconquerable spirit, he led the Lamanites forth to battle with exceeding fury against Moroni.

Moroni being in their course of march, therefore Jacob was determined to slay them and cut his way through to the city of Mulek. But behold, Moroni and his men were more powerful; therefore they did not give way before the Lamanites.

And it came to pass that they fought on both hands with exceeding fury; and there were many slain on both sides; yea, and Moroni was wounded and Jacob was killed.

And Lehi pressed upon their rear with such fury with his strong men, that the Lamanites in the rear delivered up their weapons of war; and the remainder of them, being much confused, knew not whither to go or to strike.

Now Moroni seeing their confusion, he said unto them: If ye will bring forth your weapons of war and deliver them up, behold we will forbear shedding your blood.

And it came to pass that when the Lamanites had heard these words, their chief captains, all those who were not slain, came forth and threw down their weapons of war at the feet of Moroni, and also commanded their men that they should do the same.

But behold, there were many that would not; and those who would not deliver up their swords were taken and bound, and their weapons of war were taken from them, and they were compelled to march with their brethren forth into the land Bountiful.

And now the number of prisoners who were taken exceeded more than the number of those who had been slain, yea, more than those who had been slain on both sides.

## Алма 53

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэд хоригдол леменчүүдийн дээр харуулуудыг тавьж, мөн тэднийг явж мөн өөрсдийнхөө үхэгсдийг, тийм ээ, мөн түүнчлэн алагдсан нифайчуудын шарилыг оршуулахыг албадав; мөн Моронай тэднийг ажлаа хийж байх үеэр харгалзах эрсийг тэдний дээр байрлуулав.
- 2 Мөн Моронай Лихайтай хамт Мюлек хотод очиж мөн хотын захиргааг авч мөн Лихайд үүнийг өгөв. Эдүгээ болгоогтун, энэхүү Лихай түүний бүх тулалдаануудаас ихэнхэд нь Моронайтай хамт байсан тэр хүн байв; мөн тэр Моронайтай адил эр байв. Мөн тэд нэг нэгнийнхээ аюулгүй байдалд баясдаг байв; тийм ээ, тэд нэг нэгэндээ хайрлагдсан, мөн түүнчлэн Нифайн бүх хүмүүсээр хайрлагдсан ажгуу.
- 3 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд өөрсдийн үхэгсэд мөн түүнчлэн нифайчуудын үхэгсдийг оршуулж дуусгасныхаа дараа, тэд буцаж Өгөөмөр нутагт хүргэгдэв; мөн Тианкам, Моронайн тушаалаар тэднийг Өгөөмөр нутгийг, үнэндээ бол тэр хотыг хүрээлэх шуудууг ухахаар хөдөлмөрлөж эхлэх болгов.
- 4 Мөн тэрээр тэднийг шуудууны доторх эрэг дээгүүр гуалингаар хашлага барих болгов; мөн тэд шуудуунаас шороог ухаж гуалин хашлагыг манаж овоолов; мөн гуалин мөн шороогоор үлэмж өндөр бат бэх ханаар Өгөөмөр хотыг хүрээлэх хүртэл тэд тийн леменчүүдийг хөдөлмөрлүүлэв.
- 5 Мөн энэ хот хойшид үлэмж бат бэх байхаар болгогдов; мөн энэ хотод; тийм ээ, бүр тэд, тэдний өөрсдийнх нь гараар бариулахаар албадагдсан ханын дотор леменчүүдийн олзлогдогсдыг харгалзаж байв. Эдүгээ Моронай леменчүүд хөдөлмөрлөхийг албадан шаардсан ажээ, учир нь тэднийг хөдөлмөрлөж байхад харгалзахад амар байв; мөн леменчүүдийн дээр дайралт хийх үед бүх хүчээ байлгахыг тэрээр хүсэн аж.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тийн Моронай леменчүүдийн их цэргээс хамгийн хүчирхэг нэгний дээр ялалтыг олж, мөн Нифайн нутаг дахь леменчүүдийн хамгийн бат бэх бэхлэлтийн нэгэн болох Мюлек хотыг эзэмшилдээ авчээ; мөн тийн тэрээр олзлогдогсдыг хадгалах хориглолтыг түүнчлэн барьсан байв.

## Alma 53

And it came to pass that they did set guards over the prisoners of the Lamanites, and did compel them to go forth and bury their dead, yea, and also the dead of the Nephites who were slain; and Moroni placed men over them to guard them while they should perform their labors.

And Moroni went to the city of Mulek with Lehi, and took command of the city and gave it unto Lehi. Now behold, this Lehi was a man who had been with Moroni in the more part of all his battles; and he was a man like unto Moroni, and they rejoiced in each other's safety; yea, they were beloved by each other, and also beloved by all the people of Nephi.

And it came to pass that after the Lamanites had finished burying their dead and also the dead of the Nephites, they were marched back into the land Bountiful; and Teancum, by the orders of Moroni, caused that they should commence laboring in digging a ditch round about the land, or the city, Bountiful.

And he caused that they should build a breastwork of timbers upon the inner bank of the ditch; and they cast up dirt out of the ditch against the breastwork of timbers; and thus they did cause the Lamanites to labor until they had encircled the city of Bountiful round about with a strong wall of timbers and earth, to an exceeding height.

And this city became an exceeding stronghold ever after; and in this city they did guard the prisoners of the Lamanites; yea, even within a wall which they had caused them to build with their own hands. Now Moroni was compelled to cause the Lamanites to labor, because it was easy to guard them while at their labor; and he desired all his forces when he should make an attack upon the Lamanites.

And it came to pass that Moroni had thus gained a victory over one of the greatest of the armies of the Lamanites, and had obtained possession of the city of Mulek, which was one of the strongest holds of the Lamanites in the land of Nephi; and thus he had also built a stronghold to retain his prisoners.

- 7 Мөнхүү улиран тохиох дор тэр жилдээ тэрбээр леменчүүдтэй тулалдахаар дахин оролдсонгүй, гэвч тэрбээр өөрийн хүмүүсийг дайнд бэлтгүүлж, тийм ээ, мөн түүнчлэн эхнэр мөн хүүхдүүдээ өлсгөлөн хийгээд зовлонгоос ангижруулж, мөн их цэргийнхээ хүнсийг хангахад тийм ээ, мөн түүнчлэн леменчүүдийн эсрэг хамгаалах бэхлэлтүүдийг хийхээр ажиллуулав.
- 8 Мөн эдүгээ улиран тохиох дор тэдний дунд тэрслэлийг бий болгосон тэр, нифайчуудын дундах зарим хуйвалдааны улмаас Моронайг эзгүй байх зуур, өрнөд тэнгисийн дэргэд, өмнөдөд, леменчүүдийн их цэргийнхэн нифайчуудын зарим газрыг эзэлсэн байв, тийм ээ, үүний хэрээр тэд нутгийн тэр хэсэг дэх хэд хэдэн хотыг эзэмшилдээ авсан байлаа.
- 9 Мөн тийн өөрсдийнх нь дундах алдсын учир, тийм ээ, өөрсдийнх нь дундах тэрслэл хийгээд хуйвалдаануудын учир тэд хамгийн аюултай нөхцөл байдалд тавигдав.
- 10 Мөн эдүгээ болгоогтун, Аммоны хүмүүсийн талаар, эхэндээ, леменчүүд байсан тэдний талаар хэлэх зарим зүйл надад байна; харин Аммон болон түүний ах дүүсээр үнэндээ бол Бурханы хүч мөн үгээр тэд Их Эзэнд хөрвүүлэгдсэн байв; мөн тэд Зарахемла нутаг уруу авчрагдаж, мөн тэр үеэс нифайчуудаар хамгаалагдсаар ирсэн билээ.
- 11 Мөн өөрсдийн тангаргийн учир тэд ах дүүсийнхээ эсрэг зэр зэвсэг агсах нь хориглогдсон байв; учир нь тэд дахин хэзээ ч цус урсгахгүй хэмээн тангараг өргөсөн байв; мөн тангаргийнхаа дагуу тэд мөхөх байсан бөлгөө; тийм ээ, Аммон болон түүний ах дүүсийнх тэдэнд хандуулсан өрөвч сэтгэл хийгээд үлэмжийн их хайр байгаагүйсэн бол тэд өөрсдийгөө ах дүүсийнхээ гарт орохыг тэвчих байлаа.
- 12 Мөн энэхүү шалтгааны улмаас тэд Зарахемлагийн нутагт авчрагдав; мөн тэр үеэс тэд Нифайчуудаар хамгаалагдсаар ирсэн бөлгөө.
- 13 Гэвч улиран тохиох дор тэд өөрсдийнх нь төлөө нифайчуудын үүрдэг аюулыг хийгээд олон зүдрэл хийгээд бэрхшээлүүдийг хараад, тэд нинжин сэтгэлээр догдолж мөн улс орноо хамгаалахад зэр зэвсэг агсахыг хүсч байв.

And it came to pass that he did no more attempt a battle with the Lamanites in that year, but he did employ his men in preparing for war, yea, and in making fortifications to guard against the Lamanites, yea, and also delivering their women and their children from famine and affliction, and providing food for their armies.

And now it came to pass that the armies of the Lamanites, on the west sea, south, while in the absence of Moroni on account of some intrigue amongst the Nephites, which caused dissensions amongst them, had gained some ground over the Nephites, yea, insomuch that they had obtained possession of a number of their cities in that part of the land.

And thus because of iniquity amongst themselves, yea, because of dissensions and intrigue amongst themselves they were placed in the most dangerous circumstances.

And now behold, I have somewhat to say concerning the people of Ammon, who, in the beginning, were Lamanites; but by Ammon and his brethren, or rather by the power and word of God, they had been converted unto the Lord; and they had been brought down into the land of Zarahemla, and had ever since been protected by the Nephites.

And because of their oath they had been kept from taking up arms against their brethren; for they had taken an oath that they never would shed blood more; and according to their oath they would have perished; yea, they would have suffered themselves to have fallen into the hands of their brethren, had it not been for the pity and the exceeding love which Ammon and his brethren had had for them.

And for this cause they were brought down into the land of Zarahemla; and they ever had been protected by the Nephites.

But it came to pass that when they saw the danger, and the many afflictions and tribulations which the Nephites bore for them, they were moved with compassion and were desirous to take up arms in the defence of their country.

- 14 Гэвч болгоогтун, тэд дайны зэвсгээ агсах гэж байх үед Хиламан болон түүний ах дүүсийн ятгалганд автав, учир нь тэд өргөсөн тэрхүү тангаргаасаа бараг л няцах нь холгүй байв.
- 15 Мөн тэд ийн үйлдсэнээс сүнсээрээ мөхөх вий хэмээн Хиламан айв; тиймийн тул энэхүү гэрээнд орсон тэд бүгд энэ цагт ах дүүсийнхээ аюултай нөхцөл байдал дахь зүдгүүрүүдийг туулахыг нь харахаар албадуулагдав.
- 16 Гэвч болгоогтун, улиран тохиох дор дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө хамгаалахаар дайны зэвсгүүдээ агсахгүй гэсэн гэрээнд ороогүй олон хөвгүүд тэдэнд байв; тиймийн тул энэ цагт тэд, зэр зэвсэг агсах боломжтой болгон нь өөрсдөө нэгдэн цугларч, мөн тэд өөрсдийгөө нифайчууд гэж нэрлэв.
- 17 Мөн тэд нифайчуудын эрх чөлөөний төлөө тулалдах, тийм ээ, амиа золих байсан ч уг нутгийг хамгаална гэсэн гэрээнд оржээ; тийм ээ, бүр тэд эрх чөлөөгөө хэзээ ч тавьж өгөхгүй, харин нифайчуудыг мөн өөрсдийгөө боолчлолоос хамгаалахаар тэд ямар ч нөхцөлд тулалдах болно хэмээн гэрээ хийцгээв.
- 18 Эдүгээ болгоогтун, энэхүү гэрээнд орж мөн улс орноо хамгаалахаар дайны зэвсгээ агссан нь тэдгээр залуу эрсээс хоёр мянга байв.
- 19 Мөн эдүгээ болгоогтун, тэд урьд нь ч нифайчуудад хохирол байгаагүйн адилаар, эдүгээ тэд энэ үед ч түүнчлэн агуу их дэм болов; учир нь тэд дайны зэвсгүүдээ агсаж, мөн Хиламаныг өөрсдийн удирдагч байхыг хүсэв.
- 20 Мөн тэд бүгд залуу эрс мөн тэд зориг, мөн түүнчлэн хүч чадал хийгээд эрч хүчээрээ үлэмж баатарлаг байв; гэвч болгоогтун, энэ нь бүгд бус—тэд итгэж даалгасан ямар ч зүйлд цаг ямагт үнэнч эрс байлаа.
- 21 Тийм ээ, тэд үнэн мөн чанд байдлын эрс байв, учир нь тэд Бурханы зарлигуудыг дагахыг мөн түүний өмнө зөв шударгаар алхахыг заалгасан байв.
- 22 Мөн эдүгээ улиран тохиох дор хоёр мянган залуу цэргүүдийнхээ тэргүүнд нь Хиламан, өрнөд тэнгисийн дэргэдэх өмнөд нутгийн хил дээр буй хүмүүсийг дэмжихээр жагсан одов.
- 23 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин найм дахь он тийн төгсөв.

But behold, as they were about to take their weapons of war, they were overpowered by the persuasions of Helaman and his brethren, for they were about to break the oath which they had made.

And Helaman feared lest by so doing they should lose their souls; therefore all those who had entered into this covenant were compelled to behold their brethren wade through their afflictions, in their dangerous circumstances at this time.

But behold, it came to pass they had many sons, who had not entered into a covenant that they would not take their weapons of war to defend themselves against their enemies; therefore they did assemble themselves together at this time, as many as were able to take up arms, and they called themselves Nephites.

And they entered into a covenant to fight for the liberty of the Nephites, yea, to protect the land unto the laying down of their lives; yea, even they covenanted that they never would give up their liberty, but they would fight in all cases to protect the Nephites and themselves from bondage.

Now behold, there were two thousand of those young men, who entered into this covenant and took their weapons of war to defend their country.

And now behold, as they never had hitherto been a disadvantage to the Nephites, they became now at this period of time also a great support; for they took their weapons of war, and they would that Helaman should be their leader.

And they were all young men, and they were exceedingly valiant for courage, and also for strength and activity; but behold, this was not all—they were men who were true at all times in whatsoever thing they were entrusted.

Yea, they were men of truth and soberness, for they had been taught to keep the commandments of God and to walk uprightly before him.

And now it came to pass that Helaman did march at the head of his two thousand stripling soldiers, to the support of the people in the borders of the land on the south by the west sea.

And thus ended the twenty and eighth year of the reign of the judges over the people of Nephi.

## Алма 54

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор шүүгчдийн засаглалын хорин есдүгээр оны эхэнд, Амморон хоригдлуудыг солилцохыг хүсэн тэрээр Моронайд илгээв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Моронай энэ саналд үлэмж баясмаар санагдаж, учир нь тэрээр лемен үндэсний хоригдлуудыг тэтгэхийн тулд зарцуулж байгаа хүнсийг өөрийнхөө хүмүүсийг тэтгэхийн төлөө байлгахыг хүсчээ; мөн түүнчлэн тэрээр их цэргээ хүчирхэгжүүлэхийн тулд өөрийнхөө хүмүүсийг хүсч байв.
- 3 Эдүгээ леменчүүд олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг олзолсон байв, харин Моронайн хоригдлуудын дунд нэг ч эмэгтэй хүн бас хүүхэд байсангүй; тиймийн тул Моронай нифай үндэсний аль болох олон хоригдлыг леменчүүдээс арга мэхээр авахаар шийдэв.
- 4 Тиймийн тул тэрээр захидал бичиж, мөн Моронайн захидлыг авчирсан Аммороны зарцаар үүнийгээ илгээв. Эдүгээ Амморонд бичсэн түүний үгс нь эдгээр болой, өгүүлсэн нь:
- 5 Болгоогтун, Амморон, миний хүмүүсийн эсрэг та нарын хийсэн, өөрөөр хэлбэл ахын тань тэдний эсрэг үйлдсэн, мөн түүний үхлийн дараа ч одоо хүртэл та нар үргэлжлүүлэхээр хатуу шийдсэн энэхүү дайны талаар зарим зүйлийг би танд бичиж байсан билээ.
- 6 Болгоогтун, Бурханы шударга ёсны талаар, мөн та нар наманчилж мөн их цэргээ өөрсдийнхөө нутагт, өөрөөр хэлбэл Нифайн нутаг болох, өөрсдийн эзэмшлийн нутагтаа буцаахгүй аваас та нарын дээр буухад бэлэн байгаа түүний бүхнийг чадагч хилэнгийн илдний талаар зарим зүйлийг би та нарт яримаар байна.
- 7 Тийм ээ, хэрэв та нар тэдгээрийг сонсох чадалтайсан бол би эдгээр зүйлийг та нарт хэлэхсэн; тийм ээ, та нар наманчилж мөн үхлийн зорилгуудаасаа няцаж мөн их цэрэгтэйгээ нутагтаа буцаахгүй аваас тань шиг мөн ах тань шиг тийм алуурчдыг хүлээн авахаар хүлээх тэрхүү аймшигт тамын талаар би танд хэлмээр байна.

## Alma 54

And now it came to pass in the commencement of the twenty and ninth year of the judges, that Ammoron sent unto Moroni desiring that he would exchange prisoners.

And it came to pass that Moroni felt to rejoice exceedingly at this request, for he desired the provisions which were imparted for the support of the Lamanite prisoners for the support of his own people; and he also desired his own people for the strengthening of his army.

Now the Lamanites had taken many women and children, and there was not a woman nor a child among all the prisoners of Moroni, or the prisoners whom Moroni had taken; therefore Moroni resolved upon a stratagem to obtain as many prisoners of the Nephites from the Lamanites as it were possible.

Therefore he wrote an epistle, and sent it by the servant of Ammoron, the same who had brought an epistle to Moroni. Now these are the words which he wrote unto Ammoron, saying:

Behold, Ammoron, I have written unto you somewhat concerning this war which ye have waged against my people, or rather which thy brother hath waged against them, and which ye are still determined to carry on after his death.

Behold, I would tell you somewhat concerning the justice of God, and the sword of his almighty wrath, which doth hang over you except ye repent and withdraw your armies into your own lands, or the land of your possessions, which is the land of Nephi.

Yea, I would tell you these things if ye were capable of hearkening unto them; yea, I would tell you concerning that awful hell that awaits to receive such murderers as thou and thy brother have been, except ye repent and withdraw your murderous purposes, and return with your armies to your own lands.

- 8 Гэвч та нар эдгээр зүйлийг нэгэнтээ эсэргүүцсэн, мөн Их Эзэний хүмүүсийн эсрэг тулалдсан учир, тэрчлэн би та нарыг үүнийг дахин хийх болно хэмээн бодож болох юм.
- 9 Мөн эдүгээ болгоогтун, бид та нарыг хүлээж авахад бэлтгэсэн буюу; тийм ээ, мөн та нар зорилгуудаасаа няцахгүй аваас, болгоогтун, өөрсдийнхөө эсэргүүцсэн тэр Бурханы хилэнг, өөрсдийгөө бүрмөсөн устгалд хүртэл та нар доош өөрсөд дээрээ татан авчрах болно.
- 10 Гэвч, Их Эзэн амьдын адил, та нар буцахгүй аваас бидний их цэрэг та нарын дээр очих болно, мөн та нар удалгүй үхлээр зочлогдох болно, учир нь бид хотуудаа мөн нутгаа хадгалах болно; тийм ээ, мөн бид Бурханыхаа зорилгыг мөн шашнаа хадгалан хамгаалах болно.
- 11 Гэвч болгоогтун, би эдгээр зүйлийн талаар танд ярих нь дэмий хоосон хэмээн надад санагдана; өөрөөр хэлбэл та тамын хүүхэд лугаа адил надад санагдана; тиймийн тул нэг хоригдлын төлөө та нар нэг эрийг түүний эхнэр мөн хүүхдүүдийг нь чөлөөлж ирүүлэх нөхцөлөөс бусдаар бол, би хоригдлуудыг солилцохгүйг танд хэлснээр захидлаа дуусгая; хэрэв та нар энэ нөхцөлийн дор үүнийг хийх аваас, би солилцох болно.
- 12 Мөн болгоогтун, хэрэв та нар үүнийг хийхгүй бол, би их цэрэгтэйгээ та нарын эсрэг очих болно; тийм ээ, бүр би эмэгтэйчүүдээ мөн хүүхдүүдээ ч зөвсэглэх болно, мөн би та нарын эсрэг очиж, мөн та нарыг бүр бидний анхны өв байсан өөрийн тань нутаг хүртэл дагах болно; тийм ээ, мөн энэ нь цусыг цусаар, тийм ээ, амийг амиар байх болно; мөн би та нарыг газрын гадаргуугаас үгүй болтол устгагдах хүртэл чинь та нартай тулалдан хийх болно.
- 13 Болгоогтун, би бас миний хүмүүс ч түүнчлэн ууртай байна; та нар биднийг хөнөөхыг эрэлхийлсэн, харин бид зөвхөн өөрсдийгөө өмгөөлөхийг эрэлхийлж байлаа. Гэвч болгоогтун, хэрэв та нар цаашид биднийг устгахыг эрэлхийлэх аваас бид ч та нарыг устгахыг эрэлхийлэх болно; тийм ээ, мөн бид эх нутгаа, анхныхаа өв болох нутгийг эрэлхийлэх болно.
- 14 Эдүгээ би захидлаа цэглэе. Би бол Моронай; би бол Нифайн хүмүүсийн удирдагч.

But as ye have once rejected these things, and have fought against the people of the Lord, even so I may expect you will do it again.

And now behold, we are prepared to receive you; yea, and except you withdraw your purposes, behold, ye will pull down the wrath of that God whom you have rejected upon you, even to your utter destruction.

But, as the Lord liveth, our armies shall come upon you except ye withdraw, and ye shall soon be visited with death, for we will retain our cities and our lands; yea, and we will maintain our religion and the cause of our God.

But behold, it supposeth me that I talk to you concerning these things in vain; or it supposeth me that thou art a child of hell; therefore I will close my epistle by telling you that I will not exchange prisoners, save it be on conditions that ye will deliver up a man and his wife and his children, for one prisoner; if this be the case that ye will do it, I will exchange.

And behold, if ye do not this, I will come against you with my armies; yea, even I will arm my women and my children, and I will come against you, and I will follow you even into your own land, which is the land of our first inheritance; yea, and it shall be blood for blood, yea, life for life; and I will give you battle even until you are destroyed from off the face of the earth.

Behold, I am in my anger, and also my people; ye have sought to murder us, and we have only sought to defend ourselves. But behold, if ye seek to destroy us more we will seek to destroy you; yea, and we will seek our land, the land of our first inheritance.

Now I close my epistle. I am Moroni; I am a leader of the people of the Nephites.

15 Эдүгээ улиран тохиох дор Амморон, энэ захидлыг хүлээн аваад, ууртай байв; мөн тэрээр өөр нэг захидлыг Моронайд бичив, мөн түүний бичсэн үгс нь эдгээр бөлгөө, өгүүлсэн нь:

16 Би бол Амморон, леменчүүдийн хаан; би бол та нарын алсан Амаликаягийн дүү нь. Болгоогтун, түүний цусны өшөөг би та нарт тохоох болно, тийм ээ, мөн би их цэрэгтэйгээ та нарын дээр очих болно, учир нь та нарын сүрдүүлгээс би айх нь үгүй.

17 Учир нь болгоогтун, та нарын эцэг өвгөд ах нартаа бурууг үйлдэн, үүнийхээ хэрээр тэдэнд өөрсдөд нь зүй ёсоор хамаарах, засаглах эрхийг тэд тэднээс дээрэмдэн авсан билээ.

18 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв та нар зэвсгээ хаяж, мөн өөрсдийгөө засаг төр нь зүй ёсоор хамаарагдах тэдэнд захирагдахаар харьяалуулбал, тэгвэл би өөрийн хүмүүсийг зэр зэвсгээ буулгаж мөн цаашид дайтахгүй байхаар болгоно.

19 Болгоогтун, та миний болон миний хүмүүсийн эсрэг олон сүрдүүлгийг илэрхийлжээ; гэвч болгоогтун, бид таны сүрдүүлгээс айхгүй.

20 Гэсэн хэдий ч би дайны эрсдээ зориулан хүнс нөөцөлж болохын тулд би таны саналын дагуу хоригдлуудыг солилцохыг дуртайяа зөвшөөрч байна; мөн нифайчуудыг эрх мэдэлдээ харьяалуулна эс бөгөөс тэдний мөнхийн мөхлийг хүртэл, мөнхийн байх дайныг бид хийх болно.

21 Мөн бид эсэргүүцсэн хэмээн таны хэлэх тэр Бурханы талаар бол болгоогтун, бид тийм нэгэнийг мэдэх нь үгүй; та нар ч бас мэдэх нь үгүй; гэвч хэрэв ийм нэгэн байдаг аваас, тэрээр та нарын нэгэн адил биднийг бүтээсэн байж магад хэмээн бид бодно.

22 Мөн хэрэв чөтгөр болоод там гэж байдаг аваас, болгоогтун тэрээр тийм газар одсон хэмээн таны цухуйлгасан, таны хөнөөсөн тэр ахтай минь хамт байлгахгаар тэрээр таныг тийш илгээхгүй гэж үү? Гэвч болгоогтун эдгээр зүйл хамаагүй.

23 Би бол Амморон, мөн танай эцэг өвгөдийн хүчилж мөн Иерусалимаас гаргаж авчирсан Зорамын удмын нэгэн билээ.

Now it came to pass that Ammoron, when he had received this epistle, was angry; and he wrote another epistle unto Moroni, and these are the words which he wrote, saying:

I am Ammoron, the king of the Lamanites; I am the brother of Amalickiah whom ye have murdered. Behold, I will avenge his blood upon you, yea, and I will come upon you with my armies for I fear not your threatenings.

For behold, your fathers did wrong their brethren, insomuch that they did rob them of their right to the government when it rightly belonged unto them.

And now behold, if ye will lay down your arms, and subject yourselves to be governed by those to whom the government doth rightly belong, then will I cause that my people shall lay down their weapons and shall be at war no more.

Behold, ye have breathed out many threatenings against me and my people; but behold, we fear not your threatenings.

Nevertheless, I will grant to exchange prisoners according to your request, gladly, that I may preserve my food for my men of war; and we will wage a war which shall be eternal, either to the subjecting the Nephites to our authority or to their eternal extinction.

And as concerning that God whom ye say we have rejected, behold, we know not such a being; neither do ye; but if it so be that there is such a being, we know not but that he hath made us as well as you.

And if it so be that there is a devil and a hell, behold will he not send you there to dwell with my brother whom ye have murdered, whom ye have hinted that he hath gone to such a place? But behold these things matter not.

I am Ammoron, and a descendant of Zoram, whom your fathers pressed and brought out of Jerusalem.

24 Мөнхүү болгоогтун эдүгээ, би бол лемен үндэстний сөс ихтэй нэгэн; болгоогтун, энэ дайн тэдний буруу зүйлүүдийн өшөөг авахаар дэгдээгдсэн буюу, мөн тэдний засаглах эрхүүдийг хадгалах мөн олж авахын төлөө бөлгөө; мөн би Моронайд илгээх захидлаа дуусгая.

And behold now, I am a bold Lamanite; behold, this war hath been waged to avenge their wrongs, and to maintain and to obtain their rights to the government; and I close my epistle to Moroni.



## Алма 55

- 1 Эдүгээ улиран тохиох дор Моронай энэ захидлыг хүлээн аваад тэрээр илүү ихээр уурлав, учир нь Амморон заль луйврынхаа тухай төгс мэдлэгтэйг тэр мэдэж байв; тийм ээ, Нифайн хүмүүсийн эсрэг түүнийг дайн хийхээр болгосон нь шударга шалтгаан биш гэдгийг Амморон өөрөө мэдэж буйг тэрээр мэдэж байлаа.
- 2 Мөн тэрээр хэлэв: Болгоогтун, миний захидалдаа дурдсаны адилаар, тэр зорилгоосоо няцахгүй бол би Амморонтой хоригдлуудыг солилцохгүй; учир нь би тэрээр байгаагаасаа илүү хүч чадалтай болохыг би түүнд зөвшөөрөхгүй.
- 3 Болгоогтун, леменчүүдийн хоригдлууд болгон авсан манай хүмүүсийг харгалзаж байгаа газрыг нь би мэднэ; мөн Амморон миний захидалдаа хүссэнийг зөвшөөрөөгүйн учир, болгоогтун, өөрийнхөө үгсийн дагуу би түүнд үйлдэх болно; тийм ээ, тэд энх амгаланг гуйх хүртэл нь би тэдний дунд үхлийг эрэлхийлэх болно.
- 4 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай эдгээр үгсийг хэлээд, тэрээр тэдний дундаас Леменийн удмынх болох нэг хүнийг олж болохын тулд тэрээр өөрийн хүмүүсийн дунд эрэл хийгдэх болгов.
- 5 Мөнхүү улиран тохиох дор нэр нь Лемен асан нэгийг тэд олов; мөн тэрээр Амаликаягаар алагдсан хааны зарц нарын нэг байжээ.
- 6 Эдүгээ Моронай нифайчуудыг харгалзаж байсан харуулууд дээр Леменийг мөн өөрийн хүмүүсээс цөөн хэдийг нь очих болгов.
- 7 Эдүгээ нифайчууд Гид хотод харгалзагдаж байв; тиймийн тул Моронай Леменийг томилж мөн цөөн тооны эрсийг түүнтэй явахаар болгов.
- 8 Мөн үдэш болоход Лемен нифайчуудыг харгалзаж байсан харуулууд дээр очиж, мөн болгоогтун, тэд түүний ирж явахыг хараад мөн тэд түүний зүг хашгирав; гэвч тэрээр тэдэнд хэлэв: Бүү ай; болгоогтун, би бол леменийх. Болгоогтун, бид нифайчуудаас оргон ирлээ, мөн тэд унтаж байна; мөн болгоогтун бид тэдний дарснаас авч мөн өөрсөдтэйгээ авчирлаа.

## Alma 55

Now it came to pass that when Moroni had received this epistle he was more angry, because he knew that Ammoron had a perfect knowledge of his fraud; yea, he knew that Ammoron knew that it was not a just cause that had caused him to wage a war against the people of Nephi.

And he said: Behold, I will not exchange prisoners with Ammoron save he will withdraw his purpose, as I have stated in my epistle; for I will not grant unto him that he shall have any more power than what he hath got.

Behold, I know the place where the Lamanites do guard my people whom they have taken prisoners; and as Ammoron would not grant unto me mine epistle, behold, I will give unto him according to my words; yea, I will seek death among them until they shall sue for peace.

And now it came to pass that when Moroni had said these words, he caused that a search should be made among his men, that perhaps he might find a man who was a descendant of Laman among them.

And it came to pass that they found one, whose name was Laman; and he was one of the servants of the king who was murdered by Amalickiah.

Now Moroni caused that Laman and a small number of his men should go forth unto the guards who were over the Nephites.

Now the Nephites were guarded in the city of Gid; therefore Moroni appointed Laman and caused that a small number of men should go with him.

And when it was evening Laman went to the guards who were over the Nephites, and behold, they saw him coming and they hailed him; but he saith unto them: Fear not; behold, I am a Lamanite. Behold, we have escaped from the Nephites, and they sleep; and behold we have taken of their wine and brought with us.

- 9 Эдүгээ леменчүүд эдгээр үгийг сонсоод тэд түүнийг баяртайгаар хүлээн авав; мөн тэд түүнд хэлэв: Бид ууж болохын тулд дарснаасаа бидэнд өг; та нарийн өөрсөдтэйгөө дарс авчирсанд чинь бид баяртай байна, учир нь бид ядарчээ.
- 10 Гэвч Лемен тэдэнд хэлэв: Нифайчуудын эсрэг бид тулалдахаар явах хүртлээ дарсаа хадгалцгаая. Гэвч энэ үгс нь дарснаас уух тэдний хүслийг нь л нэмэгдүүлэв;
- 11 Учир нь, тэд хэлэв: Бид ядарсан, тиймийн тул бидэнд дарснаас хүртэхийг зөвшөөр, мөн нифайчуудын эсрэг явахад биднийг хүчирхэгжүүлэх дарсны хувиа бид удахгүй авах болно.
- 12 Мөн Лемен тэдэнд хэлэв: Та нар хүслийнхээ дагуу хийж болно.
- 13 Мөнхүү улиран тохиох дор тэд дарснаас ихээр хүртэв; мөн тэдэнд амт нь таалагдаж, тиймийн тул тэд үүнээс илүү ихээр хүртэв; мөн энэ нь, үүнийг хүчтэйгээр бэлтгэсэн байсны учир хүчтэй байв.
- 14 Мөнхүү улиран тохиох дор тэд ууж мөн наргиж, мөн тэд бүгд согтоцгоов.
- 15 Мөн эдүгээ Лемен болон түүний хүмүүс тэд бүгд согтоцгоосныг бас гүн нойронд автсаныг хараад, тэд Моронайд эргэж ирээд мөн тохиолдсон бүх зүйлийг түүнд хэлэв.
- 16 Мөн эдүгээ энэ нь Моронайн төлөвлөгөөний дагуу байв. Мөн Моронай эрчүүдээ дайны зэр зэвсгээр бэлтгэсэн байв; мөн тэрээр леменчүүдийг гүн нойрондоо бас согтуу байхад нь Гид хотод очиж, мөн хоригдлуудад дайны зэвсгийг шидэж өгчээ, үүний улмаас тэд бүгд зэвсэглэгдэв;
- 17 Тийм ээ, Моронайг тэдгээр бүх хоригдлуудыг зэвсэглэхээ, бүр дайны зэвсэг хэрэглэж чадаж байсан тэдгээр бүх хүүхдүүдийг нь мөн эмэгтэйчүүдийг нь хүртэл буюу; мөн тэдгээр бүх зүйл бүрэн нам гүм байдалд хийгдэв.
- 18 Гэвч хэрэв тэд леменчүүдийг сэрээсэн бол, болгоогтун тэд согтуу байлаа мөн нифайчууд тэднийг хөнөөж чадах байв.

Now when the Lamanites heard these words they received him with joy; and they said unto him: Give us of your wine, that we may drink; we are glad that ye have thus taken wine with you for we are weary.

But Laman said unto them: Let us keep of our wine till we go against the Nephites to battle. But this saying only made them more desirous to drink of the wine;

For, said they: We are weary, therefore let us take of the wine, and by and by we shall receive wine for our rations, which will strengthen us to go against the Nephites.

And Laman said unto them: You may do according to your desires.

And it came to pass that they did take of the wine freely; and it was pleasant to their taste, therefore they took of it more freely; and it was strong, having been prepared in its strength.

And it came to pass they did drink and were merry, and by and by they were all drunken.

And now when Laman and his men saw that they were all drunken, and were in a deep sleep, they returned to Moroni and told him all the things that had happened.

And now this was according to the design of Moroni. And Moroni had prepared his men with weapons of war; and he went to the city Gid, while the Lamanites were in a deep sleep and drunken, and cast in weapons of war unto the prisoners, insomuch that they were all armed;

Yea, even to their women, and all those of their children, as many as were able to use a weapon of war, when Moroni had armed all those prisoners; and all those things were done in a profound silence.

But had they awakened the Lamanites, behold they were drunken and the Nephites could have slain them.

- 19 Гэвч болгоогтун, энэ нь Моронайн хүсэл бус байв; аллагад өөрөөр хэлбэл цус урсгахад тэр баясдаггүй байв, харин тэрээр өөрийн хүмүүсийг устгалаас аврахдаа баясдаг байв; мөн тэрээр шударга бусаар үйлдэхгүй байж болох энэхүү шалтгааны улмаас, тэрээр леменчүүдийн дээр бууж мөн тэднийг согтуу байхад нь устгасангүй ажээ.
- 20 Гэвч тэрээр хүслүүдээ гүйцээв; учир нь хотын хэрмэн дотор байсан Нифай үндэсний тэдгээр хоригдлуудыг зэвсэглэж, мөн хэрмэн дотор байсан хэсгүүдийг эзэмшилдээ авах хүчийг тэдэнд өгсөн байв.
- 21 Мөн тэгээд тэр өөртэйгөө хамт байсан эрчүүдийг тэднээс хэсэг холдуулаад, мөн леменчүүдийн их цэргийг бүслэхээр болгов.
- 22 Эдүгээ болгоогтун энэ нь шөнийн цагаар хийгдэж, иймээс леменчүүд өглөө сэрээд тэд гадуураа нифайчуудаар бүслэгдэж, мөн дотор талд хоригдлууд зэвсэглэгдсэнийг үзэв.
- 23 Мөн тэд нифайчууд тэдний дээр хүчтэйг ийн харав; мөн ийм нөхцөл байдалд тэд нифайчуудтай тулалдах нь зохимжтой бусыг олж мэдэв; тиймийн тул тэдний ерөнхий ахмад нь дайны зэвсгүүдийг нь шаардаж, мөн тэд тэдгээрийг авчирч, мөн нигүүлслийг гуйн, нифайчуудын хөлд тэдгээрийг хаяв.
- 24 Эдүгээ болгоогтун, энэ нь Моронайн хүсэл байв. Тэрээр тэднийг дайны олзлогдогсод болгон авч, мөн хотыг эзэмшилдээ аваад, мөн нифайчууд асан, бүх хоригдлуудыг чөлөөлөгдөх болгов; мөн тэд Моронайн их цэрэгт элсэж, мөн түүний их цэрэгт агуу хүч сэлбэв.
- 25 Мөнхүү улиран тохиох дор өөрийн хоригдлууд болгож баривчилсан леменчүүдийг тэрээр Гид хотыг хүрээлэх бэхлэлтүүдийг хүчирхэгжүүлэхийн тулд хөдөлмөрлөж эхлэх болгов.
- 26 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Гид хотыг өөрийн хүслүүдийн дагуу бэхлээд, тэрээр хоригдлуудыг Өгөөмөр хотод аваачигдах болгов; мөн тэрээр түүнчлэн тэр хотыг үлэмж их хүчээр хамгаалж байжээ.

But behold, this was not the desire of Moroni; he did not delight in murder or bloodshed, but he delighted in the saving of his people from destruction; and for this cause he might not bring upon him injustice, he would not fall upon the Lamanites and destroy them in their drunkenness.

But he had obtained his desires; for he had armed those prisoners of the Nephites who were within the wall of the city, and had given them power to gain possession of those parts which were within the walls.

And then he caused the men who were with him to withdraw a pace from them, and surround the armies of the Lamanites.

Now behold this was done in the night-time, so that when the Lamanites awoke in the morning they beheld that they were surrounded by the Nephites without, and that their prisoners were armed within.

And thus they saw that the Nephites had power over them; and in these circumstances they found that it was not expedient that they should fight with the Nephites; therefore their chief captains demanded their weapons of war, and they brought them forth and cast them at the feet of the Nephites, pleading for mercy.

Now behold, this was the desire of Moroni. He took them prisoners of war, and took possession of the city, and caused that all the prisoners should be liberated, who were Nephites; and they did join the army of Moroni, and were a great strength to his army.

And it came to pass that he did cause the Lamanites, whom he had taken prisoners, that they should commence a labor in strengthening the fortifications round about the city Gid.

And it came to pass that when he had fortified the city Gid, according to his desires, he caused that his prisoners should be taken to the city Bountiful; and he also guarded that city with an exceedingly strong force.

- 27 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн бүх хуйвалдаан байсаар байсан хэдий ч, тэд баривчилсан бүх хоригдлуудаа харгалзан мөн хамгаалж, мөн түүнчлэн тэд дахин олж авсан бүх нутаг дэвсгэрээ мөн давамгай байдлаа хадгалсан ажгуу.
- 28 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд дахин ялалт байгуулж, мөн эрхүүдээ мөн онцгой боломжуудаа буцаан олж эхлэв.
- 29 Олон удаа леменчүүд тэднийг шөнөөр бүслэхийг завдсан хэдий ч, эдгээр оролдлогууддаа тэд олон хүнээ хоригдол болгон алдсан ажээ.
- 30 Мөн тэднийг хороор эсвээс согтуу байхад нь устгаж болохын тулд дарснаасаа нифайчуудад өгөхийг тэд олон удаа оролджээ.
- 31 Гэвч болгоогтун, нифайчууд өөрсдийн энэ зүдгүүрийн үед Их Эзэн Бурханаа санахдаа хойрго байсангүй. Тэднийг занганд оруулах нь тэдэнд боломжгүй байв; тийм ээ, тэд эхлээд Леменийн зарим хоригдлуудад амсуулахаас бусдаар, дарснаас нь хүртэхгүй байв.
- 32 Мөн тэдний дунд ямар ч хор өгөгдөхөөргүй тийм хянамгай байв; учир нь хэрэв тэдний дарс лемен үндэстнийг хордуулбал, энэ нь түүнчлэн нифай үндэстнийг ч хордуулах болой; мөн тэд бүх архинуудыг нь тийн шалгасан бөлгөө.
- 33 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронайн хувьд Мориантан хотыг дайрах бэлтгэл хийх нь зайлшгүй шаардлагатай байв; учир нь болгоогтун, леменчүүд, өөрсдийн хөдөлмөрөөр, Мориантан хотыг үлэмж бат бэх хориглолт болтол нь бэхэлсэн байв.
- 34 Мөн тэд уг хотод нэмэгдэл хүчийг, мөн түүнчлэн хүнсний нөөц хангамжуудыг авчирсаар байв.
- 35 Мөн тийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын хорин ес дэх он төгсөв.

And it came to pass that they did, notwithstanding all the intrigues of the Lamanites, keep and protect all the prisoners whom they had taken, and also maintain all the ground and the advantage which they had re-taken.

And it came to pass that the Nephites began again to be victorious, and to reclaim their rights and their privileges.

Many times did the Lamanites attempt to encircle them about by night, but in these attempts they did lose many prisoners.

And many times did they attempt to administer of their wine to the Nephites, that they might destroy them with poison or with drunkenness.

But behold, the Nephites were not slow to remember the Lord their God in this their time of affliction. They could not be taken in their snares; yea, they would not partake of their wine, save they had first given to some of the Lamanite prisoners.

And they were thus cautious that no poison should be administered among them; for if their wine would poison a Lamanite it would also poison a Nephite; and thus they did try all their liquors.

And now it came to pass that it was expedient for Moroni to make preparations to attack the city Morianton; for behold, the Lamanites had, by their labors, fortified the city Morianton until it had become an exceeding stronghold.

And they were continually bringing new forces into that city, and also new supplies of provisions.

And thus ended the twenty and ninth year of the reign of the judges over the people of Nephi.

## Алма 56

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор шүүгчдийн засаглалын гуч дахь оны эхэнд, эхний сарын хоёр дахь өдөр, Моронай уг нутгийн тэрхүү хэсэг дэх хүмүүсийн хэрэг явдлыг тэмдэглэсэн захидлыг Хиламанаас хүлээн авлаа.
- 2 Мөн түүний бичсэн үгс нь эдгээр бөлгөө, өгүүлсэн нь: Их Эзэний хувьд түүнчлэн дайн тулаан дахь зовлон бэрхшээлүүдийн хувьд ч эрхэм хайрт ах Моронай минь; болгоогтун, хайрт ах минь, уг нутгийн энэ хэсэг дэх бидний дайны талаар танд хэлэх зарим зүйл надад байна.
- 3 Болгоогтун, Нифайн нутгаас доош Аммоны авчирсан хүмүүсийн хоёр мянган хөвгүүд—эдүгээ тэд бол бидний өвөг Лихайн ууган хүү асан лемений удам байсныг та мэдэж байгаа;
- 4 Эдүгээ тэдний уламжлалуудын эсвэл тэдний итгэлгүйн талаар танд давтах нь надад хэрэггүй, учир нь та эдгээр бүх зүйлийн талаар мэднэ—
- 5 Тиймийн тул эдгээр залуу эрсийн хоёр мянга нь дайны зэвсгүүдээ агсаж, мөн намайг удирдагчаа болоосой хэмээснийг би танд хэлэх нь хангалттай; мөн бид улс орноо хамгаалахаар урагшлан ирсэн билээ.
- 6 Мөн эдүгээ тэдний эцгүүд тэд ах дүүсийнхээ эсрэг цус урсахаар дайны зэр зэвсгээ агсахгүй хэмээн хийсэн гэрээний талаар та түүнчлэн мэднэ.
- 7 Гэвч хорин зургадугаар онд, тэд өөрсдийнх нь төлөө гэх бидний зүдгүүрүүд хийгээд бидний бэрхшээлүүдийг хараад, тэд хийсэн гэрээгээ цуцалж мөн биднийг хамгаалахын тулд дайны зэвсгүүдээ агсах гэж байв.
- 8 Гэвч тэд хийсэн гэрээгээ цуцлахыг би тэдэнд зөвшөөрөхгүй байв, Бурхан биднийг хүчирхэгжүүлэх буйза, иймээс тэд тавьсан тангаргаа биелүүлэхийн учир бид илүү ихээр зовохгүй байх болно хэмээн би бодсоноос буюу.

## Alma 56

And now it came to pass in the commencement of the thirtieth year of the reign of the judges, on the second day in the first month, Moroni received an epistle from Helaman, stating the affairs of the people in that quarter of the land.

And these are the words which he wrote, saying: My dearly beloved brother, Moroni, as well in the Lord as in the tribulations of our warfare; behold, my beloved brother, I have somewhat to tell you concerning our warfare in this part of the land.

Behold, two thousand of the sons of those men whom Ammon brought down out of the land of Nephi—now ye have known that these were descendants of Laman, who was the eldest son of our father Lehi;

Now I need not rehearse unto you concerning their traditions or their unbelief, for thou knowest concerning all these things—

Therefore it sufficeth me that I tell you that two thousand of these young men have taken their weapons of war, and would that I should be their leader; and we have come forth to defend our country.

And now ye also know concerning the covenant which their fathers made, that they would not take up their weapons of war against their brethren to shed blood.

But in the twenty and sixth year, when they saw our afflictions and our tribulations for them, they were about to break the covenant which they had made and take up their weapons of war in our defence.

But I would not suffer them that they should break this covenant which they had made, supposing that God would strengthen us, insomuch that we should not suffer more because of the fulfilling the oath which they had taken.

- 9 Гэвч болгоогтун, бид агуу баяртай байж болох нэгэн зүйл энэ байна. Учир нь болгоогтун, хорин зургаадугаар онд, би, Хиламан, эдгээр хоёр мянган залуу эрсийн тэргүүнд Иуда хотод, уг нутгийн тэр хэсгийн хүмүүсийн дээр таны удирдагчаар нь тохоосон Антипуст туслахаар жагсан одсон билээ.
- 10 Мөн хүчинд нь Антипус үлэмж баяссан тэр хоёр мянган хөвгүүдийг, (учир нь тэд хөвгүүд гэж нэрлэгдэхээр зохистой билээ) Антипусын их цэрэгт нэгтгэв; учир нь болгоогтун, леменчүүдээр түүний их цэрэг багасгагдсан байж, учир нь тэдний цэргүүд бидний эрчүүдээс тоолшгүй олныг нь алсан юм, үүний улмаас бидэнд гашуудах шалтгаан буй.
- 11 Гэсэн хэдий ч, бид энэ зүйлийн хувьд сэтгэлээ тайтгаруулж болох нь, тэд улс орон мөн Бурханыхаа хөдөлгөөний төлөө амь эрсэдсэн юм, тийм ээ, мөн тэд баяртай байгаа.
- 12 Мөн түүнчлэн леменчүүд олон хоригдлыг, бүгд ерөнхий ахмадууд болох тэднийг авч үлдсэн байв, учир нь өөр хэний ч амийг тэд хэлтрүүлсэнгүй. Мөн эдүгээ тэд энэ үед Нифайн нутагт байгаа хэмээн бид бодно; хэрэв тэд алагдаагүй бол энэ нь ийм буйза.
- 13 Мөн эдүгээ маш олон баатарлаг эрсийн маань цусыг урсгаснаар леменчүүдийн эзэмшилдээ авсан хотууд нь эдгээр болой:
- 14 Мантай нутаг, өөрөөр хэлбэл Мантай хот, мөн Зиезром хот, мөн Кууманай хот, мөн Антипара хот юм.
- 15 Мөн эдгээр нь намайг Иуда хотод хүрч ирэхэд тэдний эзэмшиж байсан тэр хотууд юм; мөн уг хотыг бэхлэн хамгаалахаар чадлаараа хөдөлмөрлөж байхад нь би Антипус болон түүний хүмүүсийг олов.
- 16 Тийм ээ, мөн тэд сэтгэлээрээ, үүний нэгэн адил биеэрээ ч сульдсан байв; учир нь тэд өдөр нь баатарлагаар тулалдаж, шөнө нь хотуудаа хадгалан хамгаалахаар хөдөлмөрлөж байв; мөн тийн тэд төрөл бүрийн агуу зовлонгуудыг тэвчсэн ажээ.
- 17 Мөн эдүгээ тэд энэ газарт ялах эс бөгөөс үхэхээр хатуу шийдсэн байв; тиймийн тул миний өөртэйгөө авчирсан тэр багахан хүч, тийм ээ, миний тэдгээр хөвгүүд, тэдэнд агуу найдлага хийгээд их баясал өгсөн хэмээн та ойлговол болно.

But behold, here is one thing in which we may have great joy. For behold, in the twenty and sixth year, I, Helaman, did march at the head of these two thousand young men to the city of Judea, to assist Antipus, whom ye had appointed a leader over the people of that part of the land.

And I did join my two thousand sons, (for they are worthy to be called sons) to the army of Antipus, in which strength Antipus did rejoice exceedingly; for behold, his army had been reduced by the Lamanites because their forces had slain a vast number of our men, for which cause we have to mourn.

Nevertheless, we may console ourselves in this point, that they have died in the cause of their country and of their God, yea, and they are happy.

And the Lamanites had also retained many prisoners, all of whom are chief captains, for none other have they spared alive. And we suppose that they are now at this time in the land of Nephi; it is so if they are not slain.

And now these are the cities of which the Lamanites have obtained possession by the shedding of the blood of so many of our valiant men:

The land of Manti, or the city of Manti, and the city of Zeezrom, and the city of Cumeni, and the city of Antiparah.

And these are the cities which they possessed when I arrived at the city of Judea; and I found Antipus and his men toiling with their might to fortify the city.

Yea, and they were depressed in body as well as in spirit, for they had fought valiantly by day and toiled by night to maintain their cities; and thus they had suffered great afflictions of every kind.

And now they were determined to conquer in this place or die; therefore you may well suppose that this little force which I brought with me, yea, those sons of mine, gave them great hopes and much joy.

18 Мөн эдүгээ улиран тохиох дор Антипус их цэрэгтээ нэмэгдэл хүч хүлээн авсныг леменчүүд хараад, тэд Иуда хотын эсрэг, өөрөөр хэлбэл бидний эсрэг тулалдахаар ирэхгүй байхыг Аммороны тушаалаар албадуулагдав.

19 Мөн бид Их Эзэний ээл хишгийг хүртэв; учир нь тэд энэ сул дорой байдалд маань бидний дээр ирсэн бол багахан цэргийг маань устгах байсан байж магад; гэвч бид тийн хамгаалагдав.

20 Тэд авсан тэр хотуудаа хадгалан хамгаалахыг Амморороор зарлиг болгогдов. Мөн хорин зургадугаар он ийн төгсөв. Мөн хорин долдугаар оны эхэнд бид хотоо мөн өөрсдийгөө батлан хамгаалахад бэлтгэсэн байв.

21 Эдүгээ бид леменчүүдийг бидний дээр ирээсэй хэмээх хүсэлтэй байв; учир нь бид тэдний хориглолтонд тэднийг довтлох хүсэлгүй байв.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд шөнөөр бас өдрөөр умард дахь манай бусад хотуудад дайралт хийхээр биднийг өнгөрөхгүй байхын тулд бид эргэн тойрондоо, леменчүүдийн хөдөлгөөнүүдийг ажиглуулахаар тандуулуудыг байлгаж байв.

23 Учир нь тэд тэр хотууддаа тэдэнтэй тулгарахад хангалттай хүчтэй байгаагүйг бид мэдэж байв; тиймийн тул хэрэв тэд бидний дэргэдүүр өнгөрвөл, бид тэдний араас нь, мөн тийн тэд урдаасаа тулгарахад нь бас нэгэн зэрэг араас нь довтлох буюу дайрах хүсэлтэй байв. Бид тэднийг дийлж чадна хэмээн бодож байв; гэвч болгоогтун, бидний энэ хүсэл бүтсэнгүй.

24 Тэд бүх их цэрэгтэйгээ ч бидний дэргэдүүр өнгөрч зүрхэлсэнгүй бас хэсгээрээ ч зүрхэлсэнгүй, тэд хангалттай хүчтэй байгаагүй болохоор тэд унах вий хэмээсэн бөлгөө.

25 Тэд бас Зарахемла хотын эсрэг жагсан очиж ч зүрхэлсэнгүй; бас тэд Нифайха хотын зүг, Сидон голын эхийг гаталж ч зүрхэлсэнгүй.

26 Мөн тийн, тэд хүчээрээ, өөрсдийн авсан хотуудыг хадгалан хамгаалахаар хатуу шийдсэн байв.

27 Мөн эдүгээ улиран тохиох дор энэ оны хоёр дахь сард, тэдгээр хоёр мянган хөвгүүдийн минь эцгүүдээс хүнсний нөөц бидэнд авчрагдав.

And now it came to pass that when the Lamanites saw that Antipus had received a greater strength to his army, they were compelled by the orders of Ammoron to not come against the city of Judea, or against us, to battle.

And thus were we favored of the Lord; for had they come upon us in this our weakness they might have perhaps destroyed our little army; but thus were we preserved.

They were commanded by Ammoron to maintain those cities which they had taken. And thus ended the twenty and sixth year. And in the commencement of the twenty and seventh year we had prepared our city and ourselves for defence.

Now we were desirous that the Lamanites should come upon us; for we were not desirous to make an attack upon them in their strongholds.

And it came to pass that we kept spies out round about, to watch the movements of the Lamanites, that they might not pass us by night nor by day to make an attack upon our other cities which were on the northward.

For we knew in those cities they were not sufficiently strong to meet them; therefore we were desirous, if they should pass by us, to fall upon them in their rear, and thus bring them up in the rear at the same time they were met in the front. We supposed that we could overpower them; but behold, we were disappointed in this our desire.

They durst not pass by us with their whole army, neither durst they with a part, lest they should not be sufficiently strong and they should fall.

Neither durst they march down against the city of Zarahemla; neither durst they cross the head of Sidon, over to the city of Nephiah.

And thus, with their forces, they were determined to maintain those cities which they had taken.

And now it came to pass in the second month of this year, there was brought unto us many provisions from the fathers of those my two thousand sons.

28 Мөн түүнчлэн Зарахемла нутгаас хоёр мянган эрс бидэнд илгээгдэв. Мөн тийн бид арван мянган эрсээр мөн тэдэнд, мөн түүнчлэн тэдний эхнэр мөн хүүхдэд нь зориулагдсан хүнсээр бид бэлтгэгдэв.

29 Мөн леменчүүд, бидний хүч өдөр бүр нэмэгдсээр, мөн биднийг дэмжих хүнс ирсээр буйг тийн харснаас, тэд айж эхлэв, мөн хэрэв боломжтойсон бол бидний хангамжууд мөн хүчийг хүлээн авахыг төгсгөл болгохоор дайрч эхлэв.

30 Эдүгээ бид леменчүүд үүндээ тэвдэж эхэлж буйг үзээд, бид тэдний дээр нэгэн зальт арга хэрэгжүүлэхийг хүсч байв; тиймийн тул Антипус намайг залуу хөвгүүдтэйгээ зэргэлдээх нэгэн хот уруу хүнс зөөж байгаа мэтээр, зэргэлдээх хотын зүг жагсан одохыг тушаав.

31 Мөн бид Антипара хотын дэргэдүүр, тэнгисийн эргээр хиллэдэг цаадах хотынх нь зүг явах гэж байгаа мэтээр, жагсан алхах ёстой байв.

32 Мөнхүү улиран тохиох дор бид хүнстэйгээ байгаа мэтээр, уг хот уруу жагсан алхав.

33 Мөнхүү улиран тохиох дор үлдэгдлийг нь уг хотыг хамгаалуулахын тулд орхиод Антипус их цэргийнхээ нэг хэсэгтэй жагсан одов. Гэвч намайг багахан цэрэгтэйгээ явж мөн Антипара хотын дэргэд ирэх хүртэл тэрээр жагсан гарч ирсэнгүй.

34 Мөн эдүгээ, Антипара хотод Леменчүүдийн хамгийн хүчирхэг цэрэг; тийм ээ, хамгийн олон тоотой нь байрласан байв.

35 Мөнхүү улиран тохиох дор тэд тандуулуудаараа мэдээлэгдсэний дараа, тэд их цэрэгтэйгээ урагшилж мөн бидний эсрэг жагсан ирэв.

36 Мөнхүү улиран тохиох дор бид тэдний өмнө нь, умардад зугтав. Мөн бид леменчүүдийн хамгийн хүчирхэг цэргийг тийн холдуулан удирдсан болой;

37 Тийм ээ, бүр нилээд их зайд, тэгсний хэрээр тэд Антипусын их цэрэг тэднийг чадлаараа мөрдөж байгааг хараад, тэд баруун тийшээ ч мөн зүүн тийшээ ч эргэсэнгүй, харин бидний араас шулуухан давшихаа үргэлжлүүлэв; мөн, бидний бодсоноор, Антипус тэднийг гүйцэхээс урьд биднийг хөнөөх нь, мөн энэ нь тэд манай хүмүүсээр бүслэгдэхгүйн тулд тэдний зорилго байв.

And also there were sent two thousand men unto us from the land of Zarahemla. And thus we were prepared with ten thousand men, and provisions for them, and also for their wives and their children.

And the Lamanites, thus seeing our forces increase daily, and provisions arrive for our support, they began to be fearful, and began to sally forth, if it were possible to put an end to our receiving provisions and strength.

Now when we saw that the Lamanites began to grow uneasy on this wise, we were desirous to bring a stratagem into effect upon them; therefore Antipus ordered that I should march forth with my little sons to a neighboring city, as if we were carrying provisions to a neighboring city.

And we were to march near the city of Antiparah, as if we were going to the city beyond, in the borders by the seashore.

And it came to pass that we did march forth, as if with our provisions, to go to that city.

And it came to pass that Antipus did march forth with a part of his army, leaving the remainder to maintain the city. But he did not march forth until I had gone forth with my little army, and came near the city Antiparah.

And now, in the city Antiparah were stationed the strongest army of the Lamanites; yea, the most numerous.

And it came to pass that when they had been informed by their spies, they came forth with their army and marched against us.

And it came to pass that we did flee before them, northward. And thus we did lead away the most powerful army of the Lamanites;

Yea, even to a considerable distance, insomuch that when they saw the army of Antipus pursuing them, with their might, they did not turn to the right nor to the left, but pursued their march in a straight course after us; and, as we suppose, it was their intent to slay us before Antipus should overtake them, and this that they might not be surrounded by our people.



38 Мөн эдүгээ Антипус, бидэнд тулгарсан аюулыг болгоож, их цэргийнхээ алхааг түргэсгэв. Гэвч болгоогтун, энэ нь шөнө байв; тиймийн тул тэд биднийг гүйцсэнгүй, бас Антипус ч тэднийг гүйцсэнгүй; тиймийн тул бид хоноглохоор буудаллав.

39 Мөнхүү улиран тохиох дор үүр цайхаас өмнө, болгоогтун, леменчүүд биднийг мөрдөж байв. Эдүгээ бид тэдэнтэй тэмцэлдэхэд хангалттай хүчирхэг байсангүй; тийм ээ, залуу хөвгүүд маань тэдний гарт орохыг би хүлцэхгүй байв; тиймийн тул бид жагсан явахаа үргэлжлүүлж, мөн бид аглаг буйд тийш жагсан одов.

40 Эдүгээ тэд бүслэгдэх болуузай хэмээснээс тэд баруун тийшээ ч бас зүүн тийшээ ч эргэж зүрхэлсэнгүй; тэд намайг гүйцэж мөн бид тэдний эсрэг зогсож чадахгүй, харин алагдаж, мөн тэд оргох вий хэмээснээс би ч бас баруун тийш ч, бас зүүн тийш ч эргэхгүй байв; мөн бид тийн бүхэл өдрийн турш бүр харанхуй болтол аглаг буйд тийш зугтав.

41 Мөнхүү улиран тохиох дор дахин, өглөөний гэгээ ороход леменчүүд бидний дээр ирж буйг бид хараад, мөн бид тэдний өмнө зугтав.

42 Гэвч улиран тохиох дор тэд биднийг хол биш мөрдөөд зогсов; мөн энэ нь долдугаар сарын гурав дахь өдрийн өглөө байв.

43 Мөн эдүгээ, тэд Антипусаар гүйцэгдсэн эсэхийг бид мэдсэнгүй, гэвч би хүмүүстээ хэлэв: Болгоогтун, тэд биднийг урхиндаа оруулж болохын тулд, биднийг өөрсдийнхөө эсрэг ирүүлэх зорилгоор азнаан зогссон эсэхийг бид мэдэхгүй;

44 Тиймийн тул та нар юу хэлнэ, хөвгүүд минь, та нар тэдний эсрэг тулалдахаар явах уу

45 Мөн эдүгээ би танд хэлье, хайрт ах Моронай минь, би хэзээ ч тийм агуу зоригийг үзээгүй, үгүй, бүх нифайчуудын дунд ч үгүй билээ.

And now Antipus, beholding our danger, did speed the march of his army. But behold, it was night; therefore they did not overtake us, neither did Antipus overtake them; therefore we did camp for the night.

And it came to pass that before the dawn of the morning, behold, the Lamanites were pursuing us. Now we were not sufficiently strong to contend with them; yea, I would not suffer that my little sons should fall into their hands; therefore we did continue our march, and we took our march into the wilderness.

Now they durst not turn to the right nor to the left lest they should be surrounded; neither would I turn to the right nor to the left lest they should overtake me, and we could not stand against them, but be slain, and they would make their escape; and thus we did flee all that day into the wilderness, even until it was dark.

And it came to pass that again, when the light of the morning came we saw the Lamanites upon us, and we did flee before them.

But it came to pass that they did not pursue us far before they halted; and it was in the morning of the third day of the seventh month.

And now, whether they were overtaken by Antipus we knew not, but I said unto my men: Behold, we know not but they have halted for the purpose that we should come against them, that they might catch us in their snare;

Therefore what say ye, my sons, will ye go against them to battle?

And now I say unto you, my beloved brother Moroni, that never had I seen so great courage, nay, not amongst all the Nephites.

46 Өөрөөр хэлбэл би тэднийг хөвгүүд минь хэмээн үргэлж дуудах болсон шиг (учир нь тэд бүгд маш залуу байв) тэрчлэн тэд надад хэлэв: Эцэг минь, Бурхан минь бид хамт гэдгийг болгоогтун, мөн тэрээр бидний унахыг хүлцэхгүй; тэгвэл биднийг урагш давшихыг зөвшөөрөөч; хэрэв тэд биднийг зүгээр орхивол бид ах дүүсээ хөнөөхгүй; тиймийн тул, тэд Антипусын их цэргийг давамгайлах болуузай хэмээн явахыг маань зөвшөөрөөч.

47 Эдүгээ тэд хэзээ ч тулалдаж байсангүй, гэсэн хэдий ч тэд үхлээс айсангүй; мөн тэд аминаасаа илүүтэйгээр эцгүүдийнхээ эрх чөлөөг бодож байв; тийм ээ, хэрэв тэд эргэлзэхгүй аваас, Бурхан тэднийг чөлөөлнө гэдэгт тэд эхчүүдээрээ сургагдсан байлаа.

48 Мөн тэд эхчүүдийнхээ үгсийг надад давтаж, хэлсэн нь: Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна.

49 Мөнхүү улиран тохиох дор биднийг мөрдөж асан леменчүүдийн эсрэг өөрийн хоёр мянгатай хамт би эргэж очлоо. Мөн эдүгээ болгоогтун, Антипусын их цэрэг тэднийг гүйцсэн байв, мөн аймшигт тулаан эхлэх нь тэр.

50 Ийм богино хугацаанд урт замыг туулсан учир, Антипусын их цэрэг ядарснаас, леменчүүдийн гарт орох магадгүй байв; мөн хэрэв би өөрийн хоёр мянгатайгаа эргэж ирээгүй бол леменчүүд зорилгодоо хүрч болохоор байв.

51 Учир нь, Антипус мөн түүний удирдагчдаас олон нь, илдэнд өртөж унасан байв, жагсан алхсан хурдаасаа болсон ядралынхаа улмаас буюу—тиймийн тул Антипусын хүмүүс, удирдагчдынхаа уналтын учир самгардсанаас, леменчүүдийн өмнө ухарч эхлэв.

52 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд зоригжин, мөн тэднийг мөрдөж эхлэв; мөн леменчүүд тийн тэднийг эрч хүчтэйгээр мөрдөж байхад Хиламан тэдний араас нь өөрийн хоёр мянгатайгаа ирж, мөн тэднийг үлэмж ихээр хөнөөж эхлэв, үүний хэрээр леменчүүдийн бүх их цэрэг зогсож мөн Хиламаны зүг эргэв.

53 Эдүгээ леменчүүд цааш хандан эргэснийг Антипусын хүмүүс хараад, тэд эрчүүдээ нэгтгэн цуглуулж мөн леменчүүдийн ар талаас дахин ирэв.

For as I had ever called them my sons (for they were all of them very young) even so they said unto me: Father, behold our God is with us, and he will not suffer that we should fall; then let us go forth; we would not slay our brethren if they would let us alone; therefore let us go, lest they should overpower the army of Antipus.

Now they never had fought, yet they did not fear death; and they did think more upon the liberty of their fathers than they did upon their lives; yea, they had been taught by their mothers, that if they did not doubt, God would deliver them.

And they rehearsed unto me the words of their mothers, saying: We do not doubt our mothers knew it.

And it came to pass that I did return with my two thousand against these Lamanites who had pursued us. And now behold, the armies of Antipus had overtaken them, and a terrible battle had commenced.

The army of Antipus being weary, because of their long march in so short a space of time, were about to fall into the hands of the Lamanites; and had I not returned with my two thousand they would have obtained their purpose.

For Antipus had fallen by the sword, and many of his leaders, because of their weariness, which was occasioned by the speed of their march—therefore the men of Antipus, being confused because of the fall of their leaders, began to give way before the Lamanites.

And it came to pass that the Lamanites took courage, and began to pursue them; and thus were the Lamanites pursuing them with great vigor when Helaman came upon their rear with his two thousand, and began to slay them exceedingly, insomuch that the whole army of the Lamanites halted and turned upon Helaman.

Now when the people of Antipus saw that the Lamanites had turned them about, they gathered together their men and came again upon the rear of the Lamanites.

54 Мөн эдүгээ улиран тохиох дор бид, Нифайн хүмүүс, Антипусын хүмүүс, мөн би хоёр мянгатайгаа, леменчүүдийг бүсэлж, мөн тэднийг хөнөөв; тийм ээ, үүний хэрээр тэд дайны зэвсгүүдээ мөн түүнчлэн өөрсдийгөө дайны олзлогдогсод болгон өгөхөөр албадуулагдав.

55 Мөн эдүгээ улиран тохиох дор тэд өөрсдийгөө бидэнд тушаан өгснийх нь дараа, болгоогтун, би надтай хамт тулалдсан тэдгээр залуу эрчүүдээ, тэднээс олон нь алагдсан байх хэмээн айснаас тоолов.

56 Гэвч болгоогтун, их баяслыг минь төрүүлэн, тэднээс нэг ч бодгаль газарт унаагүй байв; тийм ээ, мөн тэд Бурханы хүчтэй хамт мэт тулалдсан байв; тийм ээ, хүмүүн тийм гайхамшигтай хүчээр тулалдаж байсан нь хэзээ ч үзэгдэж байсангүй; мөн тэд тэднийг айлгаж ийм агуу хүчтэйгээр тэд леменчүүдийн дээр буусан бөлгөө; мөн энэ шалтгааны учир леменчүүд өөрсдийгөө дайны олзлогдогсод болгон өгсөн болой.

57 Мөн бид тэднийг леменчүүдийн их цэргээс зайдуу байлгахаар харгалзаж болохоор, олзлогдогсод зориулсан байр бидэнд байгаагүй учир, тиймийн тул бид тэднийг, Антипусын алагдаагүй үлдсэн эрчүүдийн нэгэн хэсэгтэй хамт Зарахемла нутаг уруу илгээв; мөн үлдэгдлийг нь би авч мөн залуу аммончуудтайгаа тэднийг нэгтгээд, мөн Иуда хотын зүг буцаж жагсан одов.

And now it came to pass that we, the people of Nephi, the people of Antipus, and I with my two thousand, did surround the Lamanites, and did slay them; yea, insomuch that they were compelled to deliver up their weapons of war and also themselves as prisoners of war.

And now it came to pass that when they had surrendered themselves up unto us, behold, I numbered those young men who had fought with me, fearing lest there were many of them slain.

But behold, to my great joy, there had not one soul of them fallen to the earth; yea, and they had fought as if with the strength of God; yea, never were men known to have fought with such miraculous strength; and with such mighty power did they fall upon the Lamanites, that they did frighten them; and for this cause did the Lamanites deliver themselves up as prisoners of war.

And as we had no place for our prisoners, that we could guard them to keep them from the armies of the Lamanites, therefore we sent them to the land of Zarahemla, and a part of those men who were not slain of Antipus, with them; and the remainder I took and joined them to my stripling Ammonites, and took our march back to the city of Judea.

## Алма 57

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор хаан Амморороос, хэрэв би манайхны барьсан дайны олзлогдогсдоо өгөх юм бол тэрээр Антипара хотыг бидэнд өгнө хэмээн дурдсан захидлыг би хүлээн авлаа.
- 2 Гэвч би хаанд, бидний цэргийн хүч Антипара хотыг хүчээрээ авахад хангалттайг бид лавтай мэднэ; мөн тэр хотын төлөө олзлогдогсдоо өгснөөрөө бид өөрсдийгөө ухаалаг бус хэмээн бодно, мөн бид олзлогдогсдоо зөвхөн олзлогдогсдоор солилцох болно гэсэн захидлыг илгээв.
- 3 Мөн Амморон миний хүсэлтээс татгалзав, учир нь тэр олзлогдогсдыг солилцсонгүй; тиймийн тул бид Антипара хотын эсрэг явахаар бэлтгэлүүдийг хийж эхлэв.
- 4 Гэвч Антипарагийн хүмүүс уг хотыг орхин, мөн өөрсдийн эзэмшиж асан бусад хотуудын зүг тэдгээрийг бэхлэхээр зугтав; мөн Антипара хот тийн бидний гарт оров.
- 5 Мөн шүүгчдийн засаглалын хорин найм дахь он тийн төгсөв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор хорин есдүгээр оны эхэнд, бид хүнсний хангамжуудыг, мөн түүнчлэн их цэрэгтээ нэмэлт хүч болгон миний хоёр мянгын жижиг бүлэгт ах дүүстэйгээ нэгдэхээр ирсэн аммончуудын жаран хөвгүүнийг, үүнээс гадна Зарахемла нутгаас, мөн эргэн тойрны нутгаас зургаан мянган тооны эрчүүдийг хүлээн авав. Мөн эдүгээ болгоогтун, бид хүчтэй байв, тийм ээ, мөн түүнчлэн бидэнд элбэг их хүнсний хангамжууд авчрагдсан байв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Кууманай хотыг хамгаалахаар байрлуулагдсан их цэрэгтэй тулалдах нь бидний хүсэл байв.
- 8 Мөн эдүгээ болгоогтун, бид удалгүй хүслээ биелүүлснийг танд би үзүүлэх болно; тийм ээ, хүчит цэргээрээ, өөрөөр хэлбэл хүчит цэргүүдийнхээ нэг хэсгээр, бид шөнөөр, Кууманай хотыг, тэд хүнсний хангамжаа хүлээн авахаас нь өмнөхөн тэднийг бүслэв.

## Alma 57

And now it came to pass that I received an epistle from Ammoron, the king, stating that if I would deliver up those prisoners of war whom we had taken that he would deliver up the city of Antiparah unto us.

But I sent an epistle unto the king, that we were sure our forces were sufficient to take the city of Antiparah by our force; and by delivering up the prisoners for that city we should suppose ourselves unwise, and that we would only deliver up our prisoners on exchange.

And Ammoron refused mine epistle, for he would not exchange prisoners; therefore we began to make preparations to go against the city of Antiparah.

But the people of Antiparah did leave the city, and fled to their other cities, which they had possession of, to fortify them; and thus the city of Antiparah fell into our hands.

And thus ended the twenty and eighth year of the reign of the judges.

And it came to pass that in the commencement of the twenty and ninth year, we received a supply of provisions, and also an addition to our army, from the land of Zarahemla, and from the land round about, to the number of six thousand men, besides sixty of the sons of the Ammonites who had come to join their brethren, my little band of two thousand. And now behold, we were strong, yea, and we had also plenty of provisions brought unto us.

And it came to pass that it was our desire to wage a battle with the army which was placed to protect the city Cumeni.

And now behold, I will show unto you that we soon accomplished our desire; yea, with our strong force, or with a part of our strong force, we did surround, by night, the city Cumeni, a little before they were to receive a supply of provisions.

- 9 Мөнхүү улиран тохиох дор бид олон шөнийн турш уг хотыг бүслэн буудаллав; гэвч бид илдээ дэрлэн унтаж, мөн, леменчүүд бидний дээр шөнөөр ирж мөн биднийг хөнөөж чадахгүйн тулд харуулуудыг гаргаж байв, үүнийгээ тэд олон удаа оролдов; гэвч тэд үүнийг оролдох болгондоо тэдний цус асгарсан билээ.
- 10 Хэсэг хугацааны дараа хүнсний хангамжууд нь хурч ирэв, мөн тэд шөнөөр хотод орох гэж байв. Мөн леменчүүдийн оронд, бид нифайчуудыг угтав; тиймийн тул, бид тэднийг мөн тэдний хүнсний хангамжуудыг нь авав.
- 11 Мөн леменчүүд энэ маягаар дэмжлэгээсээ таслагдсан хэдий ч, тэд хотыг хадгалан хамгаалахаар хатуу шийдсэн хэвээр байв; тиймийн тул бид тэдгээр хүнсний хангамжуудыг авч мөн тэдгээрийг Иуда уруу, мөн Зарахемлагийн нутаг дахь олзлогдогсдоо илгээх нь зайлшгүй болов.
- 12 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд тусламж авах бүх найдлагаа алдаж эхэлтэл тийм ч олон өдөр өнгөрсөнгүй; тиймийн тул тэд хотыг бидний гарт оруулав; мөн бид Кууманай хотыг олж авах төлөвлөгөөгөө тийн биелүүлсэн болой.
- 13 Гэвч улиран тохиох дор олзлогдогсод маань тийм олон тоотой байснаас, бидний тоо их олон хэдий ч, бид бүх цэргүүдээ ажиллуулж байж тэднийг харгалзуулах, эс бөгөөс тэднийг үхэлд хүргэх ёстой болов.
- 14 Учир нь болгоогтун, тэд олон тоогоороо босож, мөн чулуугаар, мөн бороохойгоор, өөрөөр хэлбэл тэд гарт нь тааралдсан болгоноор тулалдаж, үүний хэрээр тэд өөрсдийгөө дайны олзлогдогсод болгон өгсний дараа бид тэднээс хоёр мянга гаруйг нь хөнөөсөн бөлгөө.
- 15 Тиймийн тул бид амийг нь төгсгөж, эс бөгөөс гартаа илдтэйгээр Зарахемлагийн нутаг хүртэл тэднийг харгалзах нь бидний хувьд зайлшгүй болов; мөн түүнчлэн бид леменчүүдээс авсан нь байсан хэдий ч, бидний хүнсний хангамжууд хүмүүсийн маань хэрэгцээнээс илүү хангалттай байсангүй.

And it came to pass that we did camp round about the city for many nights; but we did sleep upon our swords, and keep guards, that the Lamanites could not come upon us by night and slay us, which they attempted many times; but as many times as they attempted this their blood was spilt.

At length their provisions did arrive, and they were about to enter the city by night. And we, instead of being Lamanites, were Nephites; therefore, we did take them and their provisions.

And notwithstanding the Lamanites being cut off from their support after this manner, they were still determined to maintain the city; therefore it became expedient that we should take those provisions and send them to Judea, and our prisoners to the land of Zarahemla.

And it came to pass that not many days had passed away before the Lamanites began to lose all hopes of succor; therefore they yielded up the city unto our hands; and thus we had accomplished our designs in obtaining the city Cumeni.

But it came to pass that our prisoners were so numerous that, notwithstanding the enormity of our numbers, we were obliged to employ all our force to keep them, or to put them to death.

For behold, they would break out in great numbers, and would fight with stones, and with clubs, or whatsoever thing they could get into their hands, insomuch that we did slay upwards of two thousand of them after they had surrendered themselves prisoners of war.

Therefore it became expedient for us, that we should put an end to their lives, or guard them, sword in hand, down to the land of Zarahemla; and also our provisions were not any more than sufficient for our own people, notwithstanding that which we had taken from the Lamanites.

16 Мөн эдүгээ, ийм осолтой нөхцөл байдалд, дайны эдгээр олзлогдогсдын талаар шийдвэрлэх нь маш ноцтой зүйл болов; гэсэн хэдий ч, бид тэднийг Зарахемлагийн нутаг уруу илгээхээр шийдвэрлэв; тиймийн тул бид хүмүүсээсээ нэг хэсгийг сонгон авч, мөн тэдэнд хоригдлуудаа даалгаж, Зарахемла нутаг уруу хүргэхийг тушаав.

17 Гэвч улиран тохиох дор маргааш нь тэд эргэж ирэв. Мөн эдүгээ болгоогтун, бид тэднээс хоригдлуудын талаар асуусангүй; учир нь болгоогтун, леменчүүд бидний дээр байв, мөн тэд биднийг тэдний гарт орохоос аврахаар цагаа олж эргэж ирэв. Учир нь болгоогтун, Амморон тэдэнд дэмжлэг болгон хүнсний шинэ хангамжууд мөн түүнчлэн олон тооны цэрэг эрс илгээсэн байв.

18 Мөнхүү улиран тохиох дор хоригдлуудтай хамт бидний илгээсэн тэдгээр эрс, тэд биднийг давамгайлах гэж байхад тэднийг зогсоохоор цагаа олж ирэв.

19 Гэвч болгоогтун, миний хоёр мянга жарын жижиг хэсэг туйлын ширүүн тулалдав; тийм ээ, тэд леменчүүдийн өмнө ухаршгүй байж, мөн тэдний эсрэг зогссон тэд бүгдийг үхэлд хүргэж байв.

20 Мөн манай их цэргийн үлдсэн нь леменчүүдийн өмнө ухрах гэж байхад, болгоогтун, тэрхүү хоёр мянга жар ухаршгүй мөн гуйвшгүй байв.

21 Тийм ээ, мөн тэд зарлигийн үг бүрийг яг таг гүйцэтгэхдээ дуулгавартай мөн шаргуу байв; тийм ээ, мөн бүр итгэл бишрэлийнх нь дагуу энэ нь тэдэнд хийгдсэн бөлгөө; мөн эхчүүд нь тэдэнд заасан хэмээн тэдний надад хэлсэн үгсийг би санаж байв.

22 Мөн эдүгээ болгоогтун, энэ агуу их ялалтын төлөө бид өртэй болох тэд болбоос, хоригдлуудыг хүргэхээр сонгогдсон эрчүүд, мөн миний эдгээр хөвгүүд болой; учир нь леменчүүдийг бут цохьсон нь тэд байв; тиймийн тул леменчүүд Мантай хот уруу гэдрэг туугдлаа.

23 Мөн бид Кууманай хотоо хадгалж үлдсэн буюу, мөн бүгд илдэнд устгагдсангүй; гэсэн хэдий ч, бид их хохирол хүлээв.

24 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг зугтсаны дараа, би тэр даруй үхэгсдийн дундаас шархадсан өөрийн хүмүүсийг авах тушаал өгч, мөн шархыг нь боолгох болгов.

And now, in those critical circumstances, it became a very serious matter to determine concerning these prisoners of war; nevertheless, we did resolve to send them down to the land of Zarahemla; therefore we selected a part of our men, and gave them charge over our prisoners to go down to the land of Zarahemla.

But it came to pass that on the morrow they did return. And now behold, we did not inquire of them concerning the prisoners; for behold, the Lamanites were upon us, and they returned in season to save us from falling into their hands. For behold, Ammoron had sent to their support a new supply of provisions and also a numerous army of men.

And it came to pass that those men whom we sent with the prisoners did arrive in season to check them, as they were about to overpower us.

But behold, my little band of two thousand and sixty fought most desperately; yea, they were firm before the Lamanites, and did administer death unto all those who opposed them.

And as the remainder of our army were about to give way before the Lamanites, behold, those two thousand and sixty were firm and undaunted.

Yea, and they did obey and observe to perform every word of command with exactness; yea, and even according to their faith it was done unto them; and I did remember the words which they said unto me that their mothers had taught them.

And now behold, it was these my sons, and those men who had been selected to convey the prisoners, to whom we owe this great victory; for it was they who did beat the Lamanites; therefore they were driven back to the city of Manti.

And we retained our city Cumeni, and were not all destroyed by the sword; nevertheless, we had suffered great loss.

And it came to pass that after the Lamanites had fled, I immediately gave orders that my men who had been wounded should be taken from among the dead, and caused that their wounds should be dressed.

25 Мөнхүү улиран тохиох дор миний хоёр мянга жа-  
раас цус алдсанаас ухаан алдаж унасан нь хоёр зуу  
байлаа; гэсэн хэдий ч, Бурханы сайн сайхны дагуу,  
мөн бидний үлэмж гайшрал мөн түүнчлэн бүх их  
цэргийн маань баяслыг төрүүлэн, тэднээс мөхсөн  
бодгаль нэгээхэн ч байсангүй; тийм ээ, бас тэдний  
дунд олон шарх аваагүй нэг ч бодгаль байсангүй.

26 Мөн эдүгээ, тэдний хамгаалагдан үлдсэн нь манай  
бүх их цэргийн гайхлыг төрүүлж байв, тийм ээ, бид-  
ний ах дүүсийн мянга нь алагдсан байхад тэд хэлт-  
рүүлэгдсэн байлаа. Мөн Бурханы гайхамшигт хү-  
чинд бид үүнийг шударгаар хамааруулж байна, тэд  
итгэхээр сургагдсан түүндээ итгэх үлэмж итгэлийн-  
хээ улмаас буюу, үүнд—шударга Бурхан гэж буй, мөн  
эргэлзээгүй хэн боловч, тэд түүний гайхамшигт хү-  
чээр хамгаалагдан үлдсэн байна гэдэгт бөлгөө.

27 Эдүгээ энэ нь миний тухайлан ярьсан тэдний ит-  
гэл байв; тэд залуу, мөн тэдний оюун нь өөрчлөгдөш-  
гүй, мөн тэд Бурханд найдлагаа үргэлж тавьдаг бөл-  
гөө.

28 Мөн эдүгээ улиран тохиох дор бид шархадсан эр-  
чүүдээ тийн сувилсны, мөн үхэгсдээ мөн түүнчлэн  
леменчүүдийн олон үхэгсдийг оршуулсныхаа дараа,  
болгоогтун, бид Зарахемла нутаг уруу тэдэнтэй явж  
эхэлсэн хоригдлуудын тухай Гидээс лавлав.

29 Эдүгээ Гид бол уг нутаг уруу тэднийг харгалзахаар  
тохоогдсон хэсгийн ерөнхий ахмад байв.

30 Мөн эдүгээ, Гидийн надад хэлсэн үгс нь эдгээр бо-  
лой: Болгоогтун, бид олзлогдогсодтойгоо хамт  
Зарахемла нутаг уруу явж эхлэв. Мөнхүү улиран то-  
хиох дор леменчүүдийн буудлыг ажиглахаар ил-  
гээгдсэн, их цэргийнхээ тандуулуудтай бид таарал-  
дав.

31 Мөн тэд бидэнд хашгирч, хэлсэн нь—Болгоогтун,  
леменчүүдийн их цэрэг Кууманай хотыг чиглэн жаг-  
саж явна; мөн болгоогтун, тэд тэдний дээр бууна,  
тийм ээ, мөн хүмүүсийг маань устгах болно.

32 Мөнхүү улиран тохиох дор олзлогдогсод маань  
өөрсдийг нь зоригжуулсан, тэдний хашгирааныг  
сонсов; мөн тэд бидний эсрэг тэмцэлдэхээр босов.

And it came to pass that there were two hundred, out  
of my two thousand and sixty, who had fainted because  
of the loss of blood; nevertheless, according to the  
goodness of God, and to our great astonishment, and  
also the joy of our whole army, there was not one soul of  
them who did perish; yea, and neither was there one  
soul among them who had not received many wounds.

And now, their preservation was astonishing to our  
whole army, yea, that they should be spared while there  
was a thousand of our brethren who were slain. And we  
do justly ascribe it to the miraculous power of God, be-  
cause of their exceeding faith in that which they had  
been taught to believe—that there was a just God, and  
whosoever did not doubt, that they should be preserved  
by his marvelous power.

Now this was the faith of these of whom I have spen-  
ken; they are young, and their minds are firm, and they  
do put their trust in God continually.

And now it came to pass that after we had thus taken  
care of our wounded men, and had buried our dead and  
also the dead of the Lamanites, who were many, behold,  
we did inquire of Gid concerning the prisoners whom  
they had started to go down to the land of Zarahemla  
with.

Now Gid was the chief captain over the band who  
was appointed to guard them down to the land.

And now, these are the words which Gid said unto  
me: Behold, we did start to go down to the land of  
Zarahemla with our prisoners. And it came to pass that  
we did meet the spies of our armies, who had been sent  
out to watch the camp of the Lamanites.

And they cried unto us, saying—Behold, the armies  
of the Lamanites are marching towards the city of  
Cumeni; and behold, they will fall upon them, yea, and  
will destroy our people.

And it came to pass that our prisoners did hear their  
cries, which caused them to take courage; and they did  
rise up in rebellion against us.

33 Мөнхүү улиран тохиох дор тэдний эсэргүүцлийн учир бид илдээ тэдний дээр буух болгов. Мөнхүү улиран тохиох дор тэд бөөнөөрөө бидний илдэн дор гүйн ирцгээж, ингэх зуур, тэдний олонх нь алагдав; мөн тэдний үлдсэн нь дайран гарч мөн биднээс зугтаж одов.

34 Мөн болгоогтун, тэднийг зугтахад бид тэднийг гүйцэж чадсангүй, бид Кууманай хотын зүг яаравчлан жагсаж одов; мөн болгоогтун, бид хотыг хадгалан хамгаалахад нь ах дүүстээ тусалж болохын тулд бид цагаа олж ирсэн билээ.

35 Мөн болгоогтун, бид дайснуудынхаа гараас дахин чөлөөлөгдлөө. Мөн Бурханы минь нэр алдаршиг; учир нь болгоогтун, биднийг чөлөөлсөн нь тэр бөлгөө; тийм ээ, бидний төлөө энэ агуу зүйлийг хийсэн нь тэр буюу.

36 Эдүгээ улиран тохиох дор би Хиламан, Гидийн эдгээр үгсийг сонсоод, бид бүгд мөхөхгүй байж болохын тулд, биднийг хамгаалахад үзүүлсэн Бурханы сайн сайхны учир үлэмж баяслаар халгилав; тийм ээ, мөн алагдсан тэдний бодгаль нь Бурханыхаа амралтад орсон хэмээн найдна би.

And it came to pass because of their rebellion we did cause that our swords should come upon them. And it came to pass that they did in a body run upon our swords, in the which, the greater number of them were slain; and the remainder of them broke through and fled from us.

And behold, when they had fled and we could not overtake them, we took our march with speed towards the city Cumeni; and behold, we did arrive in time that we might assist our brethren in preserving the city.

And behold, we are again delivered out of the hands of our enemies. And blessed is the name of our God; for behold, it is he that has delivered us; yea, that has done this great thing for us.

Now it came to pass that when I, Helaman, had heard these words of Gid, I was filled with exceeding joy because of the goodness of God in preserving us, that we might not all perish; yea, and I trust that the souls of them who have been slain have entered into the rest of their God.



## Алма 58

- 1 Мөн болгоогтун, эдүгээ улиран тохиох дор бидний дараагийн зорилго бол Мантай хотыг авах байв; гэвч болгоогтун, өөрсдийн багахан хэсгээр бид тэднийг хотоос гаргаж чадах ямар ч аргагүй байв. Учир нь болгоогтун, тэд бидний урьд нь юу хийснийг санаж байв; тиймийн тул бид тэднийг хориглолтуудаас нь залилан гаргаж чадсангүй.
- 2 Мөн тэд бидний их цэргээс илүү олон тоотой байснаас, бид давшин мөн хориглолтонд нь тэднийг дайрч зүрхэлсэнгүй.
- 3 Тийм ээ, бид эзэмшлийн нутгаасаа буцаан авсан хэсгүүдийг хадгалан хамгаалахын тулд өөрсдийн хүмүүсийг ажиллуулах нь бидний хувьд зайлшгүй болов; тиймийн тул бид Зарахемла нутгаас нэмэгдэл хүч мөн түүнчлэн хүнсний шинэ хангамж хүлээн авч болохын тулд, бид хүлээх нь зайлшгүй болов.
- 4 Мөнхүү улиран тохиох дор би нутгийнхаа захирагчид тийн хүмүүсийнхээ байдлын талаар танилцуулахаар элч илгээв. Мөнхүү улиран тохиох дор бид Зарахемла нутгаас хүнс болон хүч хүлээн авахыг хүлээх болов.
- 5 Гэвч болгоогтун, ингэх нь бидэнд ашиг багатай байв; учир нь леменчүүд ч түүнчлэн өдрөөс өдөрт их хүч, мөн түүнчлэн хүнсний их нөөц хүлээн авч байв; мөн энэ үед бидний нөхцөл байдал тийн байв.
- 6 Мөн леменчүүд үе үе бидний эсрэг довтолж, биднийг заль мэхээр устгахаар шийдсэн байв; гэсэн хэдий ч бид, тэдний нуувчнууд тэдний хориглолтуудын учир тэдэнтэй тулалдахаар очиж чадсангүй.
- 7 Мөнхүү улиран тохиох дор бид эдгээр хэцүү нөхцөл байдалд олон сарын турш, бүр бид хүнс дутагдсанаас эрсдэх дөхтлөө хүлээсэн билээ.
- 8 Гэвч улиран тохиох дор хоёр мянган эрстэй их цэргээр харгалзуулагдан бидэнд авчрагдсан, бидэнд тусламж болох хүнсийг бид хүлээн авсан билээ; мөн өөрсдийгөө мөн улс орноо дайснуудынхаа гарт орохоос хамгаалахаар, тийм ээ, тоолшгүй олон байсан тэр дайсантай тэмцэлдэхээр, бидний хүлээн авсан бүх тусламж энэ л юм.

## Alma 58

And behold, now it came to pass that our next object was to obtain the city of Manti; but behold, there was no way that we could lead them out of the city by our small bands. For behold, they remembered that which we had hitherto done; therefore we could not decoy them away from their strongholds.

And they were so much more numerous than was our army that we durst not go forth and attack them in their strongholds.

Yea, and it became expedient that we should employ our men to the maintaining those parts of the land which we had regained of our possessions; therefore it became expedient that we should wait, that we might receive more strength from the land of Zarahemla and also a new supply of provisions.

And it came to pass that I thus did send an embassy to the governor of our land, to acquaint him concerning the affairs of our people. And it came to pass that we did wait to receive provisions and strength from the land of Zarahemla.

But behold, this did profit us but little; for the Lamanites were also receiving great strength from day to day, and also many provisions; and thus were our circumstances at this period of time.

And the Lamanites were sallying forth against us from time to time, resolving by stratagem to destroy us; nevertheless we could not come to battle with them, because of their retreats and their strongholds.

And it came to pass that we did wait in these difficult circumstances for the space of many months, even until we were about to perish for the want of food.

But it came to pass that we did receive food, which was guarded to us by an army of two thousand men to our assistance; and this is all the assistance which we did receive, to defend ourselves and our country from falling into the hands of our enemies, yea, to contend with an enemy which was innumerable.

- 9 Мөн эдүгээ бидний эдгээр хүндрэлүүдийн шалтгааныг, эсвээс тэд бидэнд илүү нэмэгдэл хүч илгээгээгүйн шалтгааныг бид мэдсэн нь үгүй; тиймийн тул бидний уналт мөн бүрмөсөн устгалд хүргэн Бурханы шийтгэлүүд ямар нэгэн байдлаар нутаг дээр минь ирэх буюу хэмээн бид гашуудаж мөн түүнчлэн айдсаар дүүрсэн байв.
- 10 Тиймийн тул тэрээр биднийг хүчирхэгжүүлж мөн биднийг дайснуудын маань гараас чөлөөлж, тийм ээ, мөн түүнчлэн хүмүүсийнхээ дэмжлэгийн төлөө бид хотуудаа, мөн газар нутгаа, мөн эзэмшлүүдээ хадгалж болох хүчийг бидэнд түүнчлэн өгөөсэй хэмээн бид сэтгэл оюунаа Бурханд хандсан залбиралд юүлсэн болой.
- 11 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан минь, тэрээр биднийг чөлөөлөх болно хэмээх баталгаагаар бидэнд зочилсон юм; тийм ээ, үүний хэрээр тэр бидний сэтгэл оюунд амар амгаланг өгч, мөн агуу итгэлийг бидэнд соёрхож, мөн биднийг түүгээр дамжин ирэх чөлөөлөлтөндөө найдах болгосон билээ.
- 12 Мөн бид хүлээн авсан тэр багахан хүчиндээ зоригжин, мөн дайснуудаа ялахаар, мөн газар нутгаа, мөн эзэмшлүүдээ, мөн эхнэр, мөн хүүхдүүдээ, түүнчлэн эрх чөлөөний хөдөлгөөнөө хадгалан хамгаалахаар хөдөлшгүй хатуу шийдсэн байв.
- 13 Мөн бид тийн Мантай хотод байсан леменчүүдийн эсрэг бүх хүчээрээ давшив; мөн уг хотын дэргэдэх аглаг буйдын захад ойролцоо майхнуудаа босгов.
- 14 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь, бидний уг хотын дэргэдэх аглаг буйдын захад байсныг леменчүүд үзээд, тэд их цэргийн маань тоо мөн хүчийг олж мэдэж болохын тулд бидний эргэн тойронд тандуулуудаа илгээв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тооныхоо улмаас, бидний хүчтэй бишийг тэд үзээд, мөн тэд бидний эсрэг тулалдахаар гарч ирэн мөн биднийг хөнөөхгүй бол бид тэднийг дэмжлэгээс нь салгах болуузай хэмээн айж, мөн түүнчлэн өөрсдийнхөө олон тооны цэргүүдээрээ биднийг амархан устгаж чадна хэмээн бодсоны учир, тиймийн тул бидний эсрэг тулалдахаар гарч ирэхээр тэд бэлтгэлүүдийг хийж эхлэв.

And now the cause of these our embarrassments, or the cause why they did not send more strength unto us, we knew not; therefore we were grieved and also filled with fear, lest by any means the judgments of God should come upon our land, to our overthrow and utter destruction.

Therefore we did pour out our souls in prayer to God, that he would strengthen us and deliver us out of the hands of our enemies, yea, and also give us strength that we might retain our cities, and our lands, and our possessions, for the support of our people.

Yea, and it came to pass that the Lord our God did visit us with assurances that he would deliver us; yea, inasmuch that he did speak peace to our souls, and did grant unto us great faith, and did cause us that we should hope for our deliverance in him.

And we did take courage with our small force which we had received, and were fixed with a determination to conquer our enemies, and to maintain our lands, and our possessions, and our wives, and our children, and the cause of our liberty.

And thus we did go forth with all our might against the Lamanites, who were in the city of Manti; and we did pitch our tents by the wilderness side, which was near to the city.

And it came to pass that on the morrow, that when the Lamanites saw that we were in the borders by the wilderness which was near the city, that they sent out their spies round about us that they might discover the number and the strength of our army.

And it came to pass that when they saw that we were not strong, according to our numbers, and fearing that we should cut them off from their support except they should come out to battle against us and kill us, and also supposing that they could easily destroy us with their numerous hosts, therefore they began to make preparations to come out against us to battle.

- 16 Мөн тэд бидний эсрэг гарч ирэхээр бэлтгэлүүдийг хийж байсныг бид хараад, болгоогтун, би Гидийг цөөн тооны хүмүүстэй, өөрийгөө аглаг буйдад нуух, мөн түүнчлэн Тиамнерыг мөн цөөн тооны хүмүүстэй өөрсдийгөө түүнчлэн аглаг буйдад нуух болгов.
- 17 Эдүгээ Гид мөн түүний хүмүүс баруун талд мөн бусад нь зүүн талд байв; мөн тэд тийн өөрсдийгөө нууцалсны дараа, болгоогтун, би их цэргийнхээ үлдсэнтэй нь, анх майхнаа босгосон газраа леменчүүд тулалдахаар гарч ирэх цагт бэлтгэн үлдэв.
- 18 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд бидний эсрэг олон тооны их цэрэгтэйгээ гарч ирэв. Мөн тэд ирээд мөн илдтэйгээ бидний дээр буух гэж байхад нь, би хүмүүсээ, надтай байсан тэднийг, аглаг буйд тийш ухрах болгов.
- 19 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд биднийг хөнөөж болохын тулд тэд биднийг гүйцэх үлэмж хүсэлтэй байсны улмаас, тэд их хурдтайгаар бидний араас нэхсэн болой; тиймийн тул тэд биднийг аглаг буйд тийш дагав; мөн бид Гид мөн Тиамнер нарын дундуур өнгөрч, үүний хэрээр тэд леменчүүдээр илрүүлэгдсэнгүй.
- 20 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийг өнгөрсний дараа, өөрөөр хэлбэл их цэргийг нь өнгөрмөгц, Гид мөн Тиамнер нар нуугдсан газруудаасаа босож, мөн леменчүүдийн тандуулуудыг хотод эргэн очуулахгүйн тулд тэднийг тасалсан болой.
- 21 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг тасалснаа дараа, тэд хот уруу гүйж мөн хотыг харгалзахаар үлдсэн харуулууд дээр буув, үүнчлэн тэд тэднийг устгаж мөн хотыг эзэмшилдээ авсан болой.
- 22 Эдүгээ леменчүүд зөвхөн цөөн хэдэн харуулуудаас бусдыг нь, аглаг буйд тийш бүхэл их цэргээ зайцуулан удирдагдахаар болгосон учир энэ явдал тохиолдов.
- 23 Мөнхүү улиран тохиох дор Гид мөн Тиамнер нар энэ маягаар тэдний хориглолтуудыг эзэмшилдээ олж авсан байв. Мөнхүү улиран тохиох дор Зарахемлагийн нутгийн зүг аглаг буйдад ихэд аялсны дараа, бид аян замаа хөөв.

And when we saw that they were making preparations to come out against us, behold, I caused that Gid, with a small number of men, should secrete himself in the wilderness, and also that Teomner and a small number of men should secrete themselves also in the wilderness.

Now Gid and his men were on the right and the others on the left; and when they had thus secreted themselves, behold, I remained, with the remainder of my army, in that same place where we had first pitched our tents against the time that the Lamanites should come out to battle.

And it came to pass that the Lamanites did come out with their numerous army against us. And when they had come and were about to fall upon us with the sword, I caused that my men, those who were with me, should retreat into the wilderness.

And it came to pass that the Lamanites did follow after us with great speed, for they were exceedingly desirous to overtake us that they might slay us; therefore they did follow us into the wilderness; and we did pass by in the midst of Gid and Teomner, insomuch that they were not discovered by the Lamanites.

And it came to pass that when the Lamanites had passed by, or when the army had passed by, Gid and Teomner did rise up from their secret places, and did cut off the spies of the Lamanites that they should not return to the city.

And it came to pass that when they had cut them off, they ran to the city and fell upon the guards who were left to guard the city, insomuch that they did destroy them and did take possession of the city.

Now this was done because the Lamanites did suffer their whole army, save a few guards only, to be led away into the wilderness.

And it came to pass that Gid and Teomner by this means had obtained possession of their strongholds. And it came to pass that we took our course, after having traveled much in the wilderness towards the land of Zarahemla.

- 24 Мөн леменчүүд өөрсдийгөө Зарахемлагийн нутгийн зүг жагсан явж буйгаа үзээд, тэднийг устгалд хүргэх төлөвлөгөө хийгдсэн болов уу хэмээн тэд үлэмж их айв; тиймийн тул тэд аглаг буйд тийш, тийм ээ, бүр өөрсдийн ирсэн тэрхүү замаар буцаад буцан ухарч эхлэв.
- 25 Мөн болгоогтун, энэ нь шөнө байв, мөн тэд майхнуудаа босгосон байлаа, учир нь леменчүүдийн ерөнхий ахмадууд нифайчууд алхсаныхаа учир ядарсан байгаа хэмээн бодсон аж; мөн тэдний их цэргийг бүхэлд нь өмнөө байсан хэмээн бодсон учир, тиймийн тул тэд Мантай хотын талаар огт бодсонгүй.
- 26 Эдүгээ улиран тохиох дор шөнө болоход, би хүмүүсээ унталгүй, харин тэд өөр нэг замаар Мантайн нутгийн зүг урагшлан, жагсан явах болгов.
- 27 Мөн бид шөнийн цагт жагсан явсан учир, болгоогтун, маргааш нь бид леменчүүдийн цаана нь гарч, ингэснээр бид тэднээс урьд Мантайн хотод хүрч ирсэн бөлгөө.
- 28 Мөн тийн улиран тохиох дор, энэ зальт аргаар бид Мантай хотыг цус урсгалгүйгээр эзэмшилдээ авав.
- 29 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг уг хотын дэргэд хүрч ирээд, мөн бид тэдэнтэй тулгарахаар бэлтгэснийг үзээд, тэд үлэмж цочирдон мөн их айдсаар балмагдаж, ингээд тэд аглаг буйд тийш зугтав.
- 30 Тийм ээ, мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн их цэрэг уг нутгийн энэ хэсгээс гарч зугтсан болой. Гэвч болгоогтун тэд, уг нутгаас олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг өөрсөдтэйгөө авч гарав.
- 31 Мөн леменчүүдээр эзлэгдсэн тэдгээр хотууд, бүгдээрээ энэ үед бидний эзэмшилд байна; мөн эцгүүд маань мөн манай эмэгтэйчүүд мөн хүүхдүүд маань, леменчүүдээр олзлогдон аваачигдсан тэднээс бусад нь бүгд, гэртээ эргэн ирцгээж байлаа.
- 32 Гэвч болгоогтун, тийм агуу олон хотыг мөн тийм агуу эзэмшлүүдийг хадгалан хамгаалахад их цэрэг маань бага байв.

And when the Lamanites saw that they were marching towards the land of Zarahemla, they were exceedingly afraid, lest there was a plan laid to lead them on to destruction; therefore they began to retreat into the wilderness again, yea, even back by the same way which they had come.

And behold, it was night and they did pitch their tents, for the chief captains of the Lamanites had supposed that the Nephites were weary because of their march; and supposing that they had driven their whole army therefore they took no thought concerning the city of Manti.

Now it came to pass that when it was night, I caused that my men should not sleep, but that they should march forward by another way towards the land of Manti.

And because of this our march in the night-time, behold, on the morrow we were beyond the Lamanites, insomuch that we did arrive before them at the city of Manti.

And thus it came to pass, that by this stratagem we did take possession of the city of Manti without the shedding of blood.

And it came to pass that when the armies of the Lamanites did arrive near the city, and saw that we were prepared to meet them, they were astonished exceedingly and struck with great fear, insomuch that they did flee into the wilderness.

Yea, and it came to pass that the armies of the Lamanites did flee out of all this quarter of the land. But behold, they have carried with them many women and children out of the land.

And those cities which had been taken by the Lamanites, all of them are at this period of time in our possession; and our fathers and our women and our children are returning to their homes, all save it be those who have been taken prisoners and carried off by the Lamanites.

But behold, our armies are small to maintain so great a number of cities and so great possessions.

33 Гэвч болгоогтун, Бурхандаа, тэдгээр нутгуудын дээрх ялалтыг бидэнд өгсөн түүнд бид найдна, үүний хэрээр бид өөрсдийнх байсан тэдгээр хотууд мөн тэдгээр нутгуудыг авсан билээ.

34 Эдүгээ засгийн газар бидэнд илүү нэмэгдэл хүч өгөөгүйн шалтгааныг бид мэдэхгүй байна; бидэнд ирсэн тэдгээр хүмүүс ч бас бид яагаад илүү их нэмэгдэл хүч хүлээн аваагүйг мэдсэнгүй.

35 Болгоогтун, та нар амжилтгүй байж, мөн та нар нутгийн тэр хэсэгт бүх хүчийг аваачсан байж магадгүй юм; хэрэв тэгсэн бол, бид бувтналдах хүсэлгүй байна.

36 Мөн хэрэв тэгээгүй аваас, болгоогтун, засгийн газарт тэрслүү үзэл байгаагаас тэд бидэнд нэмэгдэл хүмүүсийг туслуулахаар илгээхгүй байна хэмээн бид айж байна; учир нь тэд тэдний илгээснээс илүү олон тоотойг бид мэдэж байна.

37 Гэвч болгоогтун, энэ хамаагүй—бид их цэрэг маань сул дорой ч гэсэн, Бурхан биднийг, тийм ээ, мөн дайснуудын маань гараас чөлөөлөх болно гэдэгт бид найдна.

38 Болгоогтун, энэ бол хорин ес дэх оны төгсгөл, мөн бид өөрсдийн нутгуудыг эзэмшин байна; мөн леменчүүд Нифайн нутаг тийш зугтсан байлаа.

39 Мөн миний өндрөөр үнэлэн ярьсан, Аммоны хүмүүсийн тэдгээр хөвгүүд надтай хамт Мантай хотод байна; мөн Их Эзэн тэднийг дэмжсэн, тийм ээ, мөн тэднийг илдэнд унахаас хамгаалсан, үүний үр дүнд бүр нэг ч бодгаль эрсдээгүй болой.

40 Гэвч болгоогтун, тэд олон шарх олсон; гэсэн хэдий ч тэд Бурханаар чөлөөлөгдсөн эрх чөлөөндөө бат зогсож байна; мөн тэд Их Эзэн Бурханаа өдрөөс өдөрт дурсан санахдаа хичээнгүй байдаг; тийм ээ, тэд түүний дүрмүүдийг, мөн түүний тогтоолуудыг, мөн түүний зарлигуудыг үргэлж дагахыг чармайдаг; мөн ирэх тэр зүйлийн талаарх бошиглолуудад тэдний итгэл хүчтэй байлаа.

But behold, we trust in our God who has given us victory over those lands, insomuch that we have obtained those cities and those lands, which were our own.

Now we do not know the cause that the government does not grant us more strength; neither do those men who came up unto us know why we have not received greater strength.

Behold, we do not know but what ye are unsuccessful, and ye have drawn away the forces into that quarter of the land; if so, we do not desire to murmur.

And if it is not so, behold, we fear that there is some faction in the government, that they do not send more men to our assistance; for we know that they are more numerous than that which they have sent.

But, behold, it mattereth not—we trust God will deliver us, notwithstanding the weakness of our armies, yea, and deliver us out of the hands of our enemies.

Behold, this is the twenty and ninth year, in the latter end, and we are in the possession of our lands; and the Lamanites have fled to the land of Nephi.

And those sons of the people of Ammon, of whom I have so highly spoken, are with me in the city of Manti; and the Lord has supported them, yea, and kept them from falling by the sword, insomuch that even one soul has not been slain.

But behold, they have received many wounds; nevertheless they stand fast in that liberty wherewith God has made them free; and they are strict to remember the Lord their God from day to day; yea, they do observe to keep his statutes, and his judgments, and his commandments continually; and their faith is strong in the prophecies concerning that which is to come.

41 Мөн эдүгээ, хайрт ах Моронай минь, биднийг гэтэлгэсэн мөн биднийг чөлөөтэй болгосон Их Эзэн бидний Бурхан, та нарыг үргэлж дэргэдээ байлгах болтугай; тийм ээ, мөн тэрээр энэ хүмүүсийг таалалдаа багтааг, тиймээс бүр та нар леменчүүд биднээс авсан, бидний дэмжлэгийн төлөө байсан тэр бүгдийг эзэмшилдээ олж авахад амжилттай байх болтугай. Мөн эдүгээ, болгоогтун, би захидлаа дуусгая. Би бол Алмагийн хүү, Хиламан болой.

And now, my beloved brother, Moroni, may the Lord our God, who has redeemed us and made us free, keep you continually in his presence; yea, and may he favor this people, even that ye may have success in obtaining the possession of all that which the Lamanites have taken from us, which was for our support. And now, behold, I close mine epistle. I am Helaman, the son of Alma.

## Алма 59

- 1 Эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучдугаар онд, Моронай Хиламаны захидлыг хүлээн авч, уншсаныхаа дараа, Хиламаны аз жаргалын улмаас үлэмж баясав, тийм ээ, алдагдсан тэдгээр нутгуудыг олж авахад түүний олсон үлэмж их амжилтын учир бөлгөө.
- 2 Тийм ээ, мөн тэд ч түүнчлэн баясаж болохын тулд, тэрээр өөрийнх байсан тэр хэсгийнхээ эргэн тойрны бүх нутагт дахь өөрийн бүх хүмүүст үүнийг мэдүүлэв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор Хиламан дахин олж авахдаа тийм гайхамшигтайгаар дэмжигдсэн уг нутгийн тэр хэсгийг хадгалан хамгаалахад хялбар дөхөм байж болохын тулд, Хиламаныг өөрөөр хэлбэл түүний их цэргийг хүчирхэгжүүлэхээр, хүмүүсийг нэгтгэн цуглуулахыг хүсч тэрээр тэр даруй Пахоранд захидал илгээв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор Моронай энэ захидлыг Зарахемлагийн нутагт илгээгээд, тэрээр леменчүүд тэднээс авсан тэр хотууд мөн эзэмшлүүдийн үлдсэнийг нь олж авч болохын тулд дахин төлөвлөгөө зохиож эхлэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Моронай ийн леменчүүдийн эсрэг тулалдахаар явах бэлтгэлүүдийг хийж байх зуур, болгоогтун, Моронай хотоос мөн Лихай хотоос мөн Мориантан хотоос нэгдэн цугларсан Нифайхагийн хүмүүсийг леменчүүд довтлов.
- 6 Тийм ээ, бүр Мантай нутгаас мөн эргэн тойрных нь нутгаас зугтахаас аргагүйд хүргэгдсэн тэд ирж мөн нутгийн энэ хэсэг дэх леменчүүдтэй нэгдсэн байв.
- 7 Мөн ийн тэд үлэмж олон тоотой байв, тийм ээ, мөн өдрөөс өдөрт нэмэгдэл хүч хүлээн авч байсан учир, Аммороны тушаалаар тэд Нифайхагийн хүмүүсийн эсрэг ирж, мөн тэд үлэмж их аллагаар тэднийг хөнөөж эхлэв.
- 8 Мөн тэдний их цэрэг нь тийм олон тоотой байснаас Нифайхагийн хүмүүсийн үлдэгдэл тэдний өмнө зугтахаас аргагүй болжээ; мөн тэд ирж мөн бүр Моронайн их цэрэгт нэгдэв.

## Alma 59

Now it came to pass in the thirtieth year of the reign of the judges over the people of Nephi, after Moroni had received and had read Helaman's epistle, he was exceedingly rejoiced because of the welfare, yea, the exceeding success which Helaman had had, in obtaining those lands which were lost.

Yea, and he did make it known unto all his people, in all the land round about in that part where he was, that they might rejoice also.

And it came to pass that he immediately sent an epistle to Pahoran, desiring that he should cause men to be gathered together to strengthen Helaman, or the armies of Helaman, insomuch that he might with ease maintain that part of the land which he had been so miraculously prospered in regaining.

And it came to pass when Moroni had sent this epistle to the land of Zarahemla, he began again to lay a plan that he might obtain the remainder of those possessions and cities which the Lamanites had taken from them.

And it came to pass that while Moroni was thus making preparations to go against the Lamanites to battle, behold, the people of Nephiah, who were gathered together from the city of Moroni and the city of Lehi and the city of Morianton, were attacked by the Lamanites.

Yea, even those who had been compelled to flee from the land of Manti, and from the land round about, had come over and joined the Lamanites in this part of the land.

And thus being exceedingly numerous, yea, and receiving strength from day to day, by the command of Ammoron they came forth against the people of Nephiah, and they did begin to slay them with an exceedingly great slaughter.

And their armies were so numerous that the remainder of the people of Nephiah were obliged to flee before them; and they came even and joined the army of Moroni.

9 Мөн эдүгээ леменчүүдээс үүнийг дахин авах гэснээс уг хотыг тэдний гарт орохоос хамгаалах нь илүү амархныг мэдсэн учир, уг хотыг хамгаалахад нь хүмүүст туслуулахаар Нифайха хот тийш хүмүүс илгээгдэх ёстой хэмээн Моронай бодсоноос, тэд хотыг амархан хадгалан хамгаалах болно хэмээн тэрээр боджээ.

10 Тиймийн тул тэрээр өөрийн буцааж авсан газруудаа хадгалан хамгаалахаар бүх хүчийг өөртөө авч үлдэв.

11 Мөн эдүгээ, Нифайха хот алдагдсаныг Моронай хараад, тэрээр үлэмж харамсаж, мөн хүмүүсийн ёс бус байдлын учир, тэд ах дүүсийнхээ гарт орох болов уу хэмээн эргэлзэж эхлэв.

12 Эдүгээ энэ нь түүний бүх ерөнхий ахмадуудын байдал байв. Тэд хүмүүсийн ёс бусын учир эргэлзэж мөн түүнчлэн гайхашран байв, мөн энэ нь тэдний дээрх леменчүүдийн амжилтын учир болой.

13 Мөнхүү улиран тохиох дор, улс орныхоо эрх чөлөөний талаарх тэдний хайхрамжгүйн учир Моронай засгийн газарт уурлаж байв.

And now as Moroni had supposed that there should be men sent to the city of Nephihah, to the assistance of the people to maintain that city, and knowing that it was easier to keep the city from falling into the hands of the Lamanites than to retake it from them, he supposed that they would easily maintain that city.

Therefore he retained all his force to maintain those places which he had recovered.

And now, when Moroni saw that the city of Nephihah was lost he was exceedingly sorrowful, and began to doubt, because of the wickedness of the people, whether they should not fall into the hands of their brethren.

Now this was the case with all his chief captains. They doubted and marveled also because of the wickedness of the people, and this because of the success of the Lamanites over them.

And it came to pass that Moroni was angry with the government, because of their indifference concerning the freedom of their country.



## Алма 60

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Пахоран гэгдсэн тэр, нутгийн захирагчид дахин бичив, мөн түүний бичсэн үгс нь эдгээр болой, өгүүлсэн нь: Болгоогтун, Зарахемла хот дахь, уг нутгийн дээрх захирагч мөн ерөнхий шүүгч болох Пахоранд, мөн түүнчлэн энэ хүмүүсээр энэхүү дайны хэргийг засаглан мөн удирдахаар сонгогдсон тэд бүгдэд би захидлаа хандуулж байна.
- 2 Учир нь болгоогтун, зэмлэл болгон тэдэнд хэлэх зарим зүйл надад байна; учир нь болгоогтун, эрчүүдийг нэгтгэн цуглуулахаар, мөн тэднийг сэлмээр, мөн илдээр, мөн бүхий л төрлийн дайны зүйл бүрийн зэвсгүүдээр зэвсэглэхээр, мөн леменчүүд бидний нутагт аль ч хэсгээр орж ирлээ гэсэн, тэдний эсрэг тэднийг илгээхээр та нар томилогдсоноо та нар өөрсдөө мэднэ.
- 3 Мөн эдүгээ болгоогтун, би өөрөө мөн түүнчлэн миний хүмүүс, мөн түүнчлэн Хиламан болон түүний хүмүүс үлэмж агуу зовлон зүдгүүр; тийм ээ, бүр өлсгөлөн, цангалт, мөн туйлдалт, мөн бүх зүйлийн төрөл бүрийн зүдрэлүүдийг амссаныг би та нарт хэлье.
- 4 Гэвч болгоогтун, хэрэв бидний зовсон нь үүгээр дууссан бол бид бувтналдаж мөн гомдоллохгүй байх сан.
- 5 Гэвч болгоогтун, хүмүүсийн маань дундах аллага агуу их байв; тийм ээ, хэрэв та нар их цэрэгт маань хангалттай хүчээр мөн дэмжлэгээр тэдэнд тус дэм үзүүлсэн бол өөрөөр байж болох байхад, мянга мянга нь илдэнд унагагдлаа. Тийм ээ, бидэнд хандсан хайхрамжгүй байдал тань нэтэд их байлаа.
- 6 Мөн эдүгээ болгоогтун, энэхүү үлэмж их хайхрамжгүй байдлын шалтгааныг бид мэдэх хүсэлтэй байна; тийм ээ, бодлогогүй байдлын чинь шалтгааныг бид мэдэхийг хүсч байна.
- 7 Дайснууд чинь та нарын эргэн тойронд үхлийн үйлийг тарьж байхад, та нар дүйнгэ, бодлогогүйгээр сэнтий дээрээ залрахыг бодож чадна гэж үү? Тийм ээ, тэд ах дүүсээс тань мянга мянгыг хөнөөж байхад шүү дээ—

## Alma 60

And it came to pass that he wrote again to the governor of the land, who was Pahoran, and these are the words which he wrote, saying: Behold, I direct mine epistle to Pahoran, in the city of Zarahemla, who is the chief judge and the governor over the land, and also to all those who have been chosen by this people to govern and manage the affairs of this war.

For behold, I have somewhat to say unto them by the way of condemnation; for behold, ye yourselves know that ye have been appointed to gather together men, and arm them with swords, and with cimeters, and all manner of weapons of war of every kind, and send forth against the Lamanites, in whatsoever parts they should come into our land.

And now behold, I say unto you that myself, and also my men, and also Helaman and his men, have suffered exceedingly great sufferings; yea, even hunger, thirst, and fatigue, and all manner of afflictions of every kind.

But behold, were this all we had suffered we would not murmur nor complain.

But behold, great has been the slaughter among our people; yea, thousands have fallen by the sword, while it might have otherwise been if ye had rendered unto our armies sufficient strength and succor for them. Yea, great has been your neglect towards us.

And now behold, we desire to know the cause of this exceedingly great neglect; yea, we desire to know the cause of your thoughtless state.

Can you think to sit upon your thrones in a state of thoughtless stupor, while your enemies are spreading the work of death around you? Yea, while they are murdering thousands of your brethren—

- 8 Тийм ээ, бүр хамгааллын төлөө та нар өөд харсан тэднийг, тийм ээ, та нар тэднийг дэмжиж болох байсан тэднийг, тийм ээ, та нар тэднийг хүчирхэгжүүлэхээр, тэдэнд их цэрэг илгээж, мөн тэднээс мянга мянгыг нь илдэнд унахаас аварч болох байсан тэрхүү нөхцөл байдалд та нарыг тавьсан тэднийг.
- 9 Гэвч болгоогтун, энэ нь бүгд бус—та нар хүнсээ тэднээс харамласан, үүний хэрээр энэ хүмүүсийн аз жаргалын төлөө гэсэн өөрсдөд нь байсан агуу хүслүүдийнхээ учир олон нь тулалдаж мөн тэд цусаа шавхан амиа алдсан буюу; тийм ээ, мөн та нарын тэдэнд хандсан үлэмж агуу хайхрамжгүй байдлын учир, тэд өлсгөлөнгөөр мөхөх гэж байхдаа тэд үүнийг хийсэн билээ.
- 10 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь—учир нь та нар хайрт хэмээн дуудагдахаар байвал зохино; тийм ээ, мөн та нар энэ хүмүүсийн аз жаргал хийгээд эрх чөлөөний төлөө өөрсдийгөө илүү шаргуу хөдөлгөх ёстой байсан юм; гэвч болгоогтун, та нар тэднийг үл хайхарсан, үүний хэрээр мянга мянгын цус та нарын толгой дээр өс хонзонгийн учир ирэх болно; тийм ээ, учир нь тэдний бүх хашгиралдаан, мөн тэдний бүх зүүдрэлүүд Бурханд мэдэгдсэн бөлгөө—
- 11 Болгоогтун, та нар сэнтий дээрээ заларч, мөн Бурханы үлэмж сайн сайхны учир та нар өөрсдөө юу ч хийхгүй байхад, тэрээр та нарыг чөлөөлнө хэмээн та нар бодож чадна гэж үү? Болгоогтун, хэрэв та нарын боддог бол та нар хоосныг боджээ.
- 12 Ах дүүсээс чинь ийм олон алагдсан нь өөрсдийнх нь ёс бусын учир хэмээн та нар бодно уу? Би та нарт хэлнэ, хэрэв та нар ийн бодсон аваас та нар хоосныг боджээ; учир нь би та нарт хэлнэ, илдээр унагагдсан нь олон байна; мөн болгоогтун энэ бол та нарыг ялах ял бөлгөө.
- 13 Учир нь, ёс бусыг үйлдэгчдийн дээр өөрийнх нь шударга ёс мөн шүүлт ирж болохын тулд зөв шударгыг үйлдэгсэд хөнөөгдөхийг Их Эзэн хүлцэн тэвчдэг билээ; тиймийн тул тэд алагдсан учир зөв шударгыг үйлдэгсэд алдагдсан хэмээн та нар бодох хэрэггүй; гэвч болгоогтун, тэд Их Эзэн Бурханыхаа амралтад орох болно.

Yea, even they who have looked up to you for protection, yea, have placed you in a situation that ye might have succored them, yea, ye might have sent armies unto them, to have strengthened them, and have saved thousands of them from falling by the sword.

But behold, this is not all—ye have withheld your provisions from them, insomuch that many have fought and bled out their lives because of their great desires which they had for the welfare of this people; yea, and this they have done when they were about to perish with hunger, because of your exceedingly great neglect towards them.

And now, my beloved brethren—for ye ought to be beloved; yea, and ye ought to have stirred yourselves more diligently for the welfare and the freedom of this people; but behold, ye have neglected them insomuch that the blood of thousands shall come upon your heads for vengeance; yea, for known unto God were all their cries, and all their sufferings—

Behold, could ye suppose that ye could sit upon your thrones, and because of the exceeding goodness of God ye could do nothing and he would deliver you? Behold, if ye have supposed this ye have supposed in vain.

Do ye suppose that, because so many of your brethren have been killed it is because of their wickedness? I say unto you, if ye have supposed this ye have supposed in vain; for I say unto you, there are many who have fallen by the sword; and behold it is to your condemnation;

For the Lord suffereth the righteous to be slain that his justice and judgment may come upon the wicked; therefore ye need not suppose that the righteous are lost because they are slain; but behold, they do enter into the rest of the Lord their God.

- 14 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, тэдний үлэмж залхуу хойргынх нь, тийм ээ, бүр засгийн газрын маань залхуу хойрго байдал, мөн ах дүүсдээ хандсан тэдний, тийм ээ, алагдсан тэдний зүг хандсан тэрхүү үлэмж хайхрамжгүй байдлын учир энэ хүмүүсийн дээр Бурханы шүүлтүүд ирэх болов уу хэмээн би үлэмж айж байна.
- 15 Учир нь хэрэв бидний дээрх удирдагчдаас анх эхэлсэн тэр ёс бус нь байгаагүй аваас, тэд биднийг давах хүч хуримтлуулож чадахгүй байхын тулд бид дайснуудаа сөрөн зогсож чадах байсан билээ.
- 16 Тийм ээ, өөрсдийн маань дунд гарсан тэрхүү дайнаас болоогүй сэн бол; тийм ээ, өөрсдийнхөө дунд их цус урсгахад хүргэсэн тэрхүү, хааныг хүсэгч хүмүүс байгаагүй бол; тийм ээ, өөр хоорондоо тэмцэлдэж байх тэр цагтаа, хэрэв бид урьд нь тэгснийхээ адилаар хүчээ нэгтгэсэн аваас; тийм ээ, хэрэв хааныг хүсэгч хүмүүст биднийг давах хүч чадлыг мөн эрх мэдлийг хүссэн нь байгаагүй аваас; тэд өөрсдийн маань дунд ийм их цус урсалтын шалтгаан болж, бидний эсрэг илд барихынхаа оронд, бидний эрх чөлөөний хөдөлгөөнд үнэнч байж, мөн бидэнтэй нэгдэж мөн дайснуудын маань эсрэг явсан бол; тийм ээ, хэрэв бид Их Эзэний хүчээр тэдний эсрэг явсан бол, бид дайснуудаа сарниулах байв, учир нь энэ нь түүний үгийн биелэлтийн дагуу хийгдэх байсан билээ.
- 17 Гэвч болгоогтун, эдүгээ леменчүүд бидний дээр ирж, нутгуудыг маань эзэмшилдээ авч, мөн тэд хүмүүсийг маань, тийм ээ, эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг маань илдээр хөнөөж, мөн түүнчлэн тэднийг боолчлолд аваачиж, тэднийг бүх л төрлийн зүдгүүрүүдийг тэвчихэд хүргэж байна, мөн энэ нь хүч чадал болон эрх мэдэл хайгч тэдний, тийм ээ, бүр тэдгээр хааныг хүсэгч хүмүүсийн агуу ёс бусын учир болой.
- 18 Гэвч энэ хэргийн талаар яагаад би ихийг хэлэх ёстой билээ? Учир нь та нар өөрсдөө эрх мэдлийг эрэлхийлж байгаа эсэхийг бид мэдэхгүй юм. Та нар түүнчлэн улс орноосоо урвагч эсэхийг бид мэдэхгүй юм.

And now behold, I say unto you, I fear exceedingly that the judgments of God will come upon this people, because of their exceeding slothfulness, yea, even the slothfulness of our government, and their exceedingly great neglect towards their brethren, yea, towards those who have been slain.

For were it not for the wickedness which first commenced at our head, we could have withstood our enemies that they could have gained no power over us.

Yea, had it not been for the war which broke out among ourselves; yea, were it not for these king-men, who caused so much bloodshed among ourselves; yea, at the time we were contending among ourselves, if we had united our strength as we hitherto have done; yea, had it not been for the desire of power and authority which those king-men had over us; had they been true to the cause of our freedom, and united with us, and gone forth against our enemies, instead of taking up their swords against us, which was the cause of so much bloodshed among ourselves; yea, if we had gone forth against them in the strength of the Lord, we should have dispersed our enemies, for it would have been done, according to the fulfilling of his word.

But behold, now the Lamanites are coming upon us, taking possession of our lands, and they are murdering our people with the sword, yea, our women and our children, and also carrying them away captive, causing them that they should suffer all manner of afflictions, and this because of the great wickedness of those who are seeking for power and authority, yea, even those king-men.

But why should I say much concerning this matter? For we know not but what ye yourselves are seeking for authority. We know not but what ye are also traitors to your country.

19 Эсвээс та нар бидэнд хүнс мөн түүнчлэн их цэргийг маань хүчирхэгжүүлэх эрсийг илгээх болгодоггүй нь та нар улс орны маань зүрхэнд мөн хамгаалалтаар хүрээлэгдсэн байгаа учраас, та нар биднийг эс хайхарч байна уу

20 Та нар Их Эзэн Бурханыхаа зарлигуудыг мартсан уу? Тийм ээ, та нар эцэг өвгөдөө боолчлолд байсныг мартсан уу? Бид дайснуудынхаа гараас чөлөөлөгдөж байсан олон тохиолдлыг та нар мартсан уу

21 Эсвээс Их Эзэн бидэнд соёрхсон арга замуудыг эс хэрэглэн, мөн биднийг сэнтий дээрээ заларч байхад Их Эзэн биднийг бас л чөлөөлнө хэмээн та нар бодно уу

22 Тийм ээ, нутгийн хил дээр эргэн тойронд мянга мянга нь илдэнд унагаагдаж, тийм ээ, шархдаж мөн цус алдаж байхад, залхаг байдалд залрах тэдний мянга мянгаар, тийм ээ, хэдэн арван мянгаар нь хүрээлүүлэн байхдаа, та нар ч түүнчлэн залхаг байдалд заларсаар байх уу

23 Хөдөлгөөнгүй суугаад мөн эдгээр зүйлийг харж байх зуур Бурхан та нарыг гэмгүй хэмээн үзэх болно гэж та нар бодно уу? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй. Эдүгээ дотоод хэсэг нь эхлээд цэвэршигдэж, мөн тэгээд гадаад хэсэг нь түүнчлэн цэвэрлэгдэх болно хэмээн Бурхан хэлснийг та нар санаасай хэмээнэ би.

24 Мөн эдүгээ, та нар үйлдсэнээ наманчилж, мөн идэвхийлэн мөн хийж эхлэн, мөн бидэнд мөн түүнчлэн Хиламанд, тэрээр буцаан авсан улсын маань тэдгээр хэсгийг дэмжиж болохын тулд, мөн түүнчлэн бид эдгээр хэсгүүд дэх эзэмшлүүдийнхээ үлдсэнийг нь буцаан авч болохын тулд, бидэнд хүнс мөн эрсийг илгээхгүй бол, болгоогтун бид эхлээд дотоод хэсгээ, тийм ээ, бүр засгийн газрынхаа удирдагчдыг эхлээд цэвэрлэхээс нааш леменчүүдтэй бид цаашид тэмцэлдэхгүй байх нь зүйд нийцэх ажгуу.

Or is it that ye have neglected us because ye are in the heart of our country and ye are surrounded by security, that ye do not cause food to be sent unto us, and also men to strengthen our armies?

Have ye forgotten the commandments of the Lord your God? Yea, have ye forgotten the captivity of our fathers? Have ye forgotten the many times we have been delivered out of the hands of our enemies?

Or do ye suppose that the Lord will still deliver us, while we sit upon our thrones and do not make use of the means which the Lord has provided for us?

Yea, will ye sit in idleness while ye are surrounded with thousands of those, yea, and tens of thousands, who do also sit in idleness, while there are thousands round about in the borders of the land who are falling by the sword, yea, wounded and bleeding?

Do ye suppose that God will look upon you as guiltless while ye sit still and behold these things? Behold I say unto you, Nay. Now I would that ye should remember that God has said that the inward vessel shall be cleansed first, and then shall the outer vessel be cleansed also.

And now, except ye do repent of that which ye have done, and begin to be up and doing, and send forth food and men unto us, and also unto Helaman, that he may support those parts of our country which he has regained, and that we may also recover the remainder of our possessions in these parts, behold it will be expedient that we contend no more with the Lamanites until we have first cleansed our inward vessel, yea, even the great head of our government.

25 Мөн та нар миний захидалдаа дурдсаныг зөвшөөрч, мөн эрх чөлөөнд үнэнч байдлыг надад илэрхийгээр үзүүлж, мөн их цэргийг маань хүчирхэгжүүлж мөн бэхжүүлэхээр чармайн оролдож, мөн тэдэнд дэмжлэг болгон тэдэнд хүнс өгөхгүй аваас, болгоогтун, би эрх чөлөөг хүсэгч хүмүүсийнхээ хэсгийг нутгийнхаа энэ хэсгийг хадгалан хамгаалуулахаар үлдээх болно, мөн бусад ямар ч хүч тэдний эсрэг үйлдэж чадахгүйн тулд тэдний дээр би Бурханы хүч чадал мөн адислалуудыг үлдээх болно—

26 Мөн энэ нь тэдний өөрсдийнх нь зүдгүүрүүд дэх тэвчээрийн мөн тэдний үлэмж итгэлийн учир болой—

27 Мөн та нар дээр би очих болно, мөн хэрэв та нарын дунд эрх чөлөөг хүсч буй хэн нэг нь байвал, тийм ээ, хэрэв эрх чөлөөний бүр оч ч болов үлдсэн бол, бүр хүч чадал болон эрх мэдлийг шударга бусаар эзлэхийг хүссэн тэд бүрмөсөн устах хүртэл болгоогтун би та нарын дунд бослого гаргахаар өдөөх болно.

28 Тийм ээ, болгоогтун та нарын хүч чадал бас эрх мэдлээс ч би айдаггүй, гэвч миний айх тэр нь Бурхан минь билээ; мөн эх орныхоо талыг батлан хамгаалахаар илдээ агссан минь түүний зарлигуудын дагуу билээ, мөн бид ийм их хохирол үзсэн нь та нарын алдсуудын улмаас юм.

29 Болгоогтун улс орноо мөн багачуудаа хамгаалахад та нар өөрсдийгөө дайчлахгүй аваас, шударга ёсны илд та нарын дээр далайгаастай байх цаг болжээ, тийм ээ, цаг нь ирсэн байна; тийм ээ, мөн энэ нь та нарын дээр бууж, тэр ч байтугай бүр бүрмөсөн устгалд чинь хүртэл та нарт зочлох болно.

30 Болгоогтун, би та бүгдээс тусламж хүлээж байна; мөн, та нар бидний дэмжлэгийн төлөө ажиллахгүй аваас, болгоогтун, би та нар дээр, бүр Зарахемла нутагт очиж, мөн та нарыг илдээр цохих болно, үүний хэрээр та нар цаашид энэ хүмүүс эрх чөлөөний хөдөлгөөнд хөгжихөд нь саад болох хүчтэй байж чадахгүй.

31 Учир нь болгоогтун, та нарыг амьдарч мөн түүний зөв шударга хүмүүсийг устгахаар алдсууддаа хүчтэй болохыг тань Их Эзэн тэвчихгүй.

And except ye grant mine epistle, and come out and show unto me a true spirit of freedom, and strive to strengthen and fortify our armies, and grant unto them food for their support, behold I will leave a part of my freemen to maintain this part of our land, and I will leave the strength and the blessings of God upon them, that none other power can operate against them—

And this because of their exceeding faith, and their patience in their tribulations—

And I will come unto you, and if there be any among you that has a desire for freedom, yea, if there be even a spark of freedom remaining, behold I will stir up insurrections among you, even until those who have desires to usurp power and authority shall become extinct.

Yea, behold I do not fear your power nor your authority, but it is my God whom I fear; and it is according to his commandments that I do take my sword to defend the cause of my country, and it is because of your iniquity that we have suffered so much loss.

Behold it is time, yea, the time is now at hand, that except ye do bestir yourselves in the defence of your country and your little ones, the sword of justice doth hang over you; yea, and it shall fall upon you and visit you even to your utter destruction.

Behold, I wait for assistance from you; and, except ye do administer unto our relief, behold, I come unto you, even in the land of Zarahemla, and smite you with the sword, insomuch that ye can have no more power to impede the progress of this people in the cause of our freedom.

For behold, the Lord will not suffer that ye shall live and wax strong in your iniquities to destroy his righteous people.

32 Болгоогтун, та нарын алдас энэ дэлхийн нэр алдар болон хоосон зүйлийг хайрлах хайраас чинь шалтгаалж байгаа бол, эцэг өвгөдийнх нь уламжлал тэдний үзэн ядалтыг бий болгож, тийм ээ, мөн энэ нь биднээс тэрсэлсэн тэднээр хэд дахин нэмэгдсэн байхад, Их Эзэн леменчүүдийн дээр буруушаалтуудыг ноогдуулж мөн та нарыг хэлтрүүлэх болно хэмээн та нар бодож чадах уу

33 Та нар Бурханы хуулиудыг зөрчдөгөө мэднэ, мөн та нар тэдгээрийг хөл дороо дэвсэлдгээ мэднэ. Болгоогтун: Хэрэв та нарын томилсон захирагчид чинь нүглүүдээ мөн алдсуудаа наманчлахгүй аваас, та нар тэдний эсрэг тулалдахаар явах болно хэмээн Их Эзэн надад хэлдэг.

34 Мөн эдүгээ болгоогтун, Бурханыхаа зарлигуудыг би дагана хэмээн хийсэн тэрхүү гэрээний дагуу Моронай би албадуулагдсан болой; тиймийн тул та нар Бурханы үгийг дагаасай, мөн надад мөн түүнчлэн Хиламанд хүнснээсээ болон хүмүүсээсээ яаралтай илгээгээсэй хэмээнэ би.

35 Мөн болгоогтун, хэрэв та нар үүнийг хийхгүй аваас би та нар дээр яаралтай очно; учир нь болгоогтун, биднийг өлсгөлөнгөөр мөхөхийг Бурхан тэвчихгүй; тиймийн тул хэрэв энэ нь бүр илдээр хийгдэх ёстой болсон ч та нарын хүнснээс тэрээр бидэнд өгөх болно. Эдүгээ та нар Бурханы үгийг биелүүлэхээ мэдээрэй.

36 Болгоогтун, би бол Моронай, та нараар тохоогдсон ерөнхий ахмад. Би удирдан захирах хүчийг бус, харин үүнийг устган зайлуулахыг эрэлхийлнэ. Би дэлхийн нэр төрийг эрэлхийлдэггүй, харин Бурханыхаа алдар сууг мөн улс орныхоо эрх чөлөө мөн аз жаргалыг болой. Мөн би захидлаа ийн дуусгая.

Behold, can you suppose that the Lord will spare you and come out in judgment against the Lamanites, when it is the tradition of their fathers that has caused their hatred, yea, and it has been redoubled by those who have dissented from us, while your iniquity is for the cause of your love of glory and the vain things of the world?

Ye know that ye do transgress the laws of God, and ye do know that ye do trample them under your feet. Behold, the Lord saith unto me: If those whom ye have appointed your governors do not repent of their sins and iniquities, ye shall go up to battle against them.

And now behold, I, Moroni, am constrained, according to the covenant which I have made to keep the commandments of my God; therefore I would that ye should adhere to the word of God, and send speedily unto me of your provisions and of your men, and also to Helaman.

And behold, if ye will not do this I come unto you speedily; for behold, God will not suffer that we should perish with hunger; therefore he will give unto us of your food, even if it must be by the sword. Now see that ye fulfil the word of God.

Behold, I am Moroni, your chief captain. I seek not for power, but to pull it down. I seek not for honor of the world, but for the glory of my God, and the freedom and welfare of my country. And thus I close mine epistle.

## Алма 61

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Моронай өөрийн захидлыг ерөнхий захирагчид илгээснээс хойш удалгүй, тэрээр ерөнхий захирагч Пахоранаас захидал хүлээн авав. Мөн түүний хүлээн авсан үгс нь эдгээр болой:
- 2 Энэ нутгийн ерөнхий засаглагч болох Пахоран, би, эдгээр үгсийг их цэргийн дээрх ерөнхий ахмад Моронайд илгээж байна. Болгоогтун, би чамд хэлнэ, Моронай, би та нарын их зүдгүүрүүдэд баясдаггүй, тийм ээ, энэ нь сэтгэлийг минь шаналгаж байна.
- 3 Гэвч болгоогтун, та нарын зүдгүүрүүдэд баясах тэд буй, тийм ээ, үүний хэрээр тэд миний эсрэг мөн түүнчлэн миний хүмүүсээс эрх чөлөөг хүсэгч хүмүүс болох тэдний эсрэг эсэргүүцэлд босч байна, тийм ээ, мөн боссон тэд үлэмж олон тоотой бөлгөө.
- 4 Мөн надаас шүүлтийн суудлыг авахыг эрэлхийлсэн тэд бол энэ агуу алдсын шалтгаан юм; тодруулбал тэд агуу зусардалт хэрэглэж, мөн тэд олон хүмүүний зүрх сэтгэлийг зайцуулан удирдсан нь бидний дундах гашуун зовлонгийн шалтгаан байх болно; тэд хүнсийг маань саатуулж, мөн эрх чөлөөг хүсэгч хүмүүсийг маань сүрдүүлснээс тэдгээр нь та нар дээр очоогүй.
- 5 Мөн болгоогтун, тэд намайг өөрсдийнхөө өмнөөс зайлуулж, мөн би Гидеоны нутагт, би дагуулж чадах бүх эрчүүдтэйгээ хамт зугтаж ирлээ.
- 6 Мөн болгоогтун, уг нутгийн энэ хэсэг даяар би тунхаг илгээсэн билээ; мөн болгоогтун, улс орноо мөн эрх чөлөөгөө батлан хамгаалахад мөн бидний эсрэг үйлдэгдсэнээс өшөө авахад, зэвсэг агсахаар тэд өдрөөс өдөрт нэмэгдэн цуглацгааж байна.
- 7 Мөн тэд бидэнд ирж, үүнчлэн бидний эсрэг эсэргүүцэлд босогчид илэрхийгээр эсэргүүцэгдэв, тийм ээ, үүний хэрээр тэд биднээс айж мөн бидний эсрэг тулалдахаар ирж зүрхэлсэнгүй.

## Alma 61

Behold, now it came to pass that soon after Moroni had sent his epistle unto the chief governor, he received an epistle from Pahoran, the chief governor. And these are the words which he received:

I, Pahoran, who am the chief governor of this land, do send these words unto Moroni, the chief captain over the army. Behold, I say unto you, Moroni, that I do not joy in your great afflictions, yea, it grieves my soul.

But behold, there are those who do joy in your afflictions, yea, insomuch that they have risen up in rebellion against me, and also those of my people who are freemen, yea, and those who have risen up are exceedingly numerous.

And it is those who have sought to take away the judgment-seat from me that have been the cause of this great iniquity; for they have used great flattery, and they have led away the hearts of many people, which will be the cause of sore affliction among us; they have withheld our provisions, and have daunted our freemen that they have not come unto you.

And behold, they have driven me out before them, and I have fled to the land of Gideon, with as many men as it were possible that I could get.

And behold, I have sent a proclamation throughout this part of the land; and behold, they are flocking to us daily, to their arms, in the defence of their country and their freedom, and to avenge our wrongs.

And they have come unto us, insomuch that those who have risen up in rebellion against us are set at defiance, yea, insomuch that they do fear us and durst not come out against us to battle.

8 Тэд Зарахемла нутгийг, өөрөөр хэлбэл уг хотыг эзэмшилдээ авлаа; тэд дээрээ хааныг тохоож, мөн тэрээр леменчүүдийн хаанд бичжээ, үүндээ тэрээр түүнтэй холбоотон болон нэгдсэн ажээ; энэ хуйвалдаандаа тэрээр Зарахемла хотыг хадгалан хамгаалыхыг зөвшөөрсөн аж, ийн хадгалан хамгаалснаар үлдсэн бүх нутгийг эзлэн авах бололцоог леменчүүдэд олгож, мөн леменчүүдэд тэд ялагдах үед энэ хүмүүсийн дээр өөрөө хаанаар тохоогдох болно хэмээн тэр боджээ.

9 Мөн эдүгээ, чи захидалдаа намайг буруутгажээ, гэвч энэ нь хамаагүй; би уурлаагүй, харин сэтгэлийн чинь агуу ихэд баясна. Пахоран, миний бие хүмүүсийнхээ эрх хийгээд чөлөөт байдлыг хадгалж болохын тулд зөвхөн шүүлтийн суудлаа авч үлдэхээс өөр хүчийг би эрэлхийлдэггүй. Бурхан биднийг чөлөөтэй болгосон тэрхүү эрх чөлөөнд бодгаль минь бат зогсоно.

10 Мөн эдүгээ, болгоогтун, бид ёс бусыг, бүр цус урсгах хүртлээ эсэргүүцэх болно. Хэрэв леменчүүд нутаг дээрээ үлдвэл, бид тэдний цусыг урсгахгүй.

11 Хэрэв тэд бидний эсрэг эсэргүүцэлд босохгүй мөн илд агсахгүй аваас бид ах дүүсийнхээ цусыг урсгахгүй.

12 Хэрэв энэ нь Бурханы шударга ёсонд шаардагдсан аваас, өөрөөр хэлбэл хэрэв тэр бидэнд түүнчлэн үйлдэхийг зарлигласан аваас бид өөрсдийгөө боолчлолын буулганд харьяалуулах болно.

13 Гэвч болгоогтун тэрээр өөрсдийгөө дайснууддаа харьяалуулахыг бус, харин бид түүнд найдлагаа тавихыг бидэнд зарлиг болгодог, мөн тэр биднийг чөлөөлөх болно.

14 Тиймийн тул, хайрт ах минь, Моронай, хилэнцтэйн эсрэг сөрөн зогсоцгооё, мөн бид үгсээрээ сөрөн зогсож чадахгүй хилэнцэт болох юуг боловч, тийм ээ, бид эрх чөлөөгөө хадгалж болохын тулд, бид сүмийнхээ агуу боломжинд, мөн өөрсдийн Гэтэлгэгч бөгөөд Бурханыхаа хэрэгт баясаж болохын тулд зөрчил болоод тэмцлүүд гэх мэтийг илдээрээ эсэргүүцэцгээе.

They have got possession of the land, or the city, of Zarahemla; they have appointed a king over them, and he hath written unto the king of the Lamanites, in the which he hath joined an alliance with him; in the which alliance he hath agreed to maintain the city of Zarahemla, which maintenance he supposeth will enable the Lamanites to conquer the remainder of the land, and he shall be placed king over this people when they shall be conquered under the Lamanites.

And now, in your epistle you have censured me, but it mattereth not; I am not angry, but do rejoice in the greatness of your heart. I, Pahoran, do not seek for power, save only to retain my judgment-seat that I may preserve the rights and the liberty of my people. My soul standeth fast in that liberty in the which God hath made us free.

And now, behold, we will resist wickedness even unto bloodshed. We would not shed the blood of the Lamanites if they would stay in their own land.

We would not shed the blood of our brethren if they would not rise up in rebellion and take the sword against us.

We would subject ourselves to the yoke of bondage if it were requisite with the justice of God, or if he should command us so to do.

But behold he doth not command us that we shall subject ourselves to our enemies, but that we should put our trust in him, and he will deliver us.

Therefore, my beloved brother, Moroni, let us resist evil, and whatsoever evil we cannot resist with our words, yea, such as rebellions and dissensions, let us resist them with our swords, that we may retain our freedom, that we may rejoice in the great privilege of our church, and in the cause of our Redeemer and our God.



- 15 Тиймийн тул, эрчүүдээсээ цөөнийг нь авч надад яаралтай ир, мөн үлдсэнийг нь Лихай болон Тианкамын мэдэлд орхи; тэдэнд уг нутгийн тэр хэсэгт, түүнчлэн тэдэнд орших эрх чөлөөний төлөөх сэтгэл болох Бурханы Сүнсний дагуу дайныг удирдах эрх мэдлийг тэдэнд өгөгтүн.
- 16 Болгоогтун та нарыг надад ирэх хүртэл тэд мөхөхгүй байж болохын тулд би тэдэнд цөөн хангамж илгээлээ.
- 17 Нааш ирэх замдаа чадахынхаа хэрээр хүчийг нэгтгэн цуглуул, мөн бидэнд буй итгэлийн дагуу Бурханыхаа хүчээр бид тэдгээр тэрслэгчдийн эсрэг хурдан явах болно.
- 18 Мөн бид Лихай Тианкам нарт илгээх илүү хоол хүнс олж болохын тулд, бид Зарахемлагийн хотыг эзэмшилдээ авах болно; тийм ээ, бид Их Эзэний хүчээр тэдний эсрэг явах болно, мөн бид энэ агуу алдсыг төгсгөх болно.
- 19 Мөн эдүгээ, Моронай, би захидлыг чинь хүлээн авсандаа баясаж байна. Учир нь бид юу хийх талаар, ах дүүсийнхээ эсрэг явах нь бидний хувьд шударга эсэх талаар би бага зэрэг санаа зовж байлаа.
- 20 Гэвч тэд наманчлахгүй аваас чи тэдний эсрэг явахыг Их Эзэн чамд зарлигласныг чи хэлжээ.
- 21 Лихай Тианкам нарыг Их Эзэний хувьд чи хүчирхэгжүүлэхээ мэдэгтүн; тэднийг, тийм ээ, мөн түүнчлэн тэдэнд Бурханы өгсөн тэрхүү эрх чөлөөнд бат зогссон тэд бүгдийг Бурхан чөлөөлөх учир бүү ай хэмээн тэдэнд хэл. Мөн эдүгээ хайрт ах, Моронайдаа зориулсан захидлаа би дуусгая.

Therefore, come unto me speedily with a few of your men, and leave the remainder in the charge of Lehi and Teancum; give unto them power to conduct the war in that part of the land, according to the Spirit of God, which is also the spirit of freedom which is in them.

Behold I have sent a few provisions unto them, that they may not perish until ye can come unto me.

Gather together whatsoever force ye can upon your march hither, and we will go speedily against those dissenters, in the strength of our God according to the faith which is in us.

And we will take possession of the city of Zarahemla, that we may obtain more food to send forth unto Lehi and Teancum; yea, we will go forth against them in the strength of the Lord, and we will put an end to this great iniquity.

And now, Moroni, I do joy in receiving your epistle, for I was somewhat worried concerning what we should do, whether it should be just in us to go against our brethren.

But ye have said, except they repent the Lord hath commanded you that ye should go against them.

See that ye strengthen Lehi and Teancum in the Lord; tell them to fear not, for God will deliver them, yea, and also all those who stand fast in that liberty wherewith God hath made them free. And now I close mine epistle to my beloved brother, Moroni.

## Алма 62

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Моронай энэ захидлыг хүлээн аваад түүний зүрх зоригийг олон, мөн Пахоран эрх чөлөө хийгээд улс орныхоо талаас түүнчлэн урвалгүй, үнэнч байсны учир, тэрээр үлэмж их баяслаар халгилан байв.
- 2 Гэвч тэрээр түүнчлэн Пахораныг шүүлтийн суудлаас зайлуулсан тэдний алдсын учир, тийм ээ, эцэст нь улс орныхоо мөн түүнчлэн Бурханыхаа эсрэг эсэргүүцсэн тэдний учир үлэмж харамсан гашуудав.
- 3 Мөнхүү улиран тохиох дор Пахораны хүслийн дагуу Моронай цөөн тооны эрсийг авч, мөн их цэргийнхээ үлдсэн хэсгийн удирдлагыг Лихай Тианкам нарт өгч, мөн Гидеоны нутгийн зүг жагсан одов.
- 4 Мөн тэрээр орсон газар болгондоо эрх чөлөөний далбаа босгож, мөн Гидеоны нутгийн зүг алхах зуураа чадах чинээгээрээ бүхий л хүчийг нэгтгэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор мянга мянга нь түүний тугийн дор цуглаж, мөн тэд боолчлолд орохгүй байж болохын тулд, эрх чөлөөгөө хамгаалахаар илдээ агсацгаав.
- 6 Мөн тийн, Моронай жагсан явах бүхий л замдаа чадахын хэрээр бүх эрчүүдийг нэгтгэн цуглуулаад, тэрээр Гидеоны нутагт ирэв; мөн өөрийн хүчийг Пахораны тэдэнтэй нэгтгээд тэд үлэмж хүчтэй болов, бүр эрх чөлөөг хүсэгч хүмүүсийг Зарахемлагийн нутгаас гаргаж мөн уг нутгийг эзэмшилдээ авсан тэрслэгчдийн хаан асан Пакусын хүмүүсээс ч илүү хүчтэй болов.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Моронай Пахоран нар их цэрэгтэйгээ Зарахемлагийн нутаг уруу очиж, мөн хотын эсрэг давшиж, мөн Пакусын хүмүүстэй тулгарч, үүнчлэн тэд тулалдахад хүрсэн ажгуу.
- 8 Мөн болгоогтун, Пакус алагдаж, мөн түүний хүмүүс олзлогдож, мөн Пахоран шүүлтийн суудалдаа сэргээгдэв.
- 9 Мөн Пакусын хүмүүс, мөн түүнчлэн баривчлагдсан мөн шоронд хаягдсан хааныг хүсэгч хүмүүс хуулийн дагуу шүүгдсэн бөлгөө; мөн тэд хуулийн дагуу яллагдсан ажээ; тийм ээ, улс орноо хамгаалахаар зэвсэг агсахгүй, харин үүний эсрэг тулалдах гэсэн тэр болгон, Пакусын эдгээр хүмүүс мөн хааныг хүсэгч хүмүүс үхэлд хүргэгдэв.

## Alma 62

And now it came to pass that when Moroni had received this epistle his heart did take courage, and was filled with exceedingly great joy because of the faithfulness of Pahoran, that he was not also a traitor to the freedom and cause of his country.

But he did also mourn exceedingly because of the iniquity of those who had driven Pahoran from the judgment-seat, yea, in fine because of those who had rebelled against their country and also their God.

And it came to pass that Moroni took a small number of men, according to the desire of Pahoran, and gave Lehi and Teancum command over the remainder of his army, and took his march towards the land of Gideon.

And he did raise the standard of liberty in whatsoever place he did enter, and gained whatsoever force he could in all his march towards the land of Gideon.

And it came to pass that thousands did flock unto his standard, and did take up their swords in the defence of their freedom, that they might not come into bondage.

And thus, when Moroni had gathered together whatsoever men he could in all his march, he came to the land of Gideon; and uniting his forces with those of Pahoran they became exceedingly strong, even stronger than the men of Pachus, who was the king of those dissenters who had driven the freemen out of the land of Zarahemla and had taken possession of the land.

And it came to pass that Moroni and Pahoran went down with their armies into the land of Zarahemla, and went forth against the city, and did meet the men of Pachus, insomuch that they did come to battle.

And behold, Pachus was slain and his men were taken prisoners, and Pahoran was restored to his judgment-seat.

And the men of Pachus received their trial, according to the law, and also those king-men who had been taken and cast into prison; and they were executed according to the law; yea, those men of Pachus and those king-men, whosoever would not take up arms in the defence of their country, but would fight against it, were put to death.

- 10 Мөн улс орных нь аюулгүй байдлын тулд хууль ха-  
туу чандаар мөрдөгдөх нь тийн зайлшгүй болов;  
тийм ээ, мөн эрх чөлөөгөө үгүйсгэж байгаа нь илч-  
лэгдсэн хэн боловч хуулийн дагуу яаралтай яллаг-  
даж байв.
- 11 Мөн ийн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн за-  
саглалын гучдугаар он төгсөв; эрх чөлөөний хөдөл-  
гөөнд үнэнч байгаагүй тэд бүгдийг үхлээр шийтгэж  
Моронай Пахоран нар Зарахемлагийн нутагт, өө-  
рийн хүмүүсийн дунд, амар амгаланг сэргээв.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн  
дээрх шүүгчдийн засаглалын гучин нэгдүгээр оны  
эхэнд, Моронай тэр даруй хангамжуудыг илгээгдэ-  
хээр, мөн түүнчлэн зургаан мянган эрстэй их цэрэг  
Хиламанд, нутгийн тэр хэсгийг хадгалж үлдэхийн  
тулд түүнд туслуулахаар илгээгдэхээр болгов.
- 13 Мөн түүнчлэн тэрээр зургаан мянган эрстэй их  
цэрэг, хангалттай хэмжээний хүнстэйгээр, Лихай  
Тианкам нарын их цэрэг тийш илгээгдэхээр болгов.  
Мөнхүү улиран тохиох дор энэ нь леменчүүдийн эс-  
рэг уг нутгийг бэхлэхээр хийгдсэн аж.
- 14 Мөнхүү улиран тохиох дор Моронай Пахоран  
нар хүмүүсийнхээ томоохон бүлгийг Зарахемлагийн  
нутагт орхиж, хүмүүсийнхээ томоохон бүлэгтэй  
хамт Нифайхагийн нутгийн зүг жагсан одов, тэд уг  
хот дахь леменчүүдийг дийлэхээр хатуу шийдсэний  
учир болой.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутгийн зүг жаг-  
сан явж байхдаа, тэд леменчүүдийн хүмүүсийн то-  
моохон хэсгийг баривчилж, мөн тэднээс олныг нь  
алж, мөн тэдний хангамжууд хийгээд дайны зэр  
зэвсгүүдийг нь авав.
- 16 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг барив-  
чилсныхаа дараа, тэд цаашид нифайчуудын эсрэг  
дайны зэр зэвсгээ агсахгүй гэсэн гэрээнд тэднийг  
орох болгов.
- 17 Мөн тэднийг энэ гэрээнд орсны дараа, тэд  
Аммоны хүмүүстэй оршин суулгахаар тэднийг ил-  
гээж, мөн алагдаагүй тэд тоогоороо дөрвөн мянга  
орчим байв.

And thus it became expedient that this law should be  
strictly observed for the safety of their country; yea, and  
whosoever was found denying their freedom was speed-  
ily executed according to the law.

And thus ended the thirtieth year of the reign of the  
judges over the people of Nephi; Moroni and Pahoran  
having restored peace to the land of Zarahemla, among  
their own people, having inflicted death upon all those  
who were not true to the cause of freedom.

And it came to pass in the commencement of the  
thirty and first year of the reign of the judges over the  
people of Nephi, Moroni immediately caused that pro-  
visions should be sent, and also an army of six thousand  
men should be sent unto Helaman, to assist him in pre-  
serving that part of the land.

And he also caused that an army of six thousand  
men, with a sufficient quantity of food, should be sent  
to the armies of Lehi and Teancum. And it came to pass  
that this was done to fortify the land against the  
Lamanites.

And it came to pass that Moroni and Pahoran, leav-  
ing a large body of men in the land of Zarahemla, took  
their march with a large body of men towards the land  
of Nephiah, being determined to overthrow the  
Lamanites in that city.

And it came to pass that as they were marching to-  
wards the land, they took a large body of men of the  
Lamanites, and slew many of them, and took their pro-  
visions and their weapons of war.

And it came to pass after they had taken them, they  
caused them to enter into a covenant that they would  
no more take up their weapons of war against the  
Nephites.

And when they had entered into this covenant they  
sent them to dwell with the people of Ammon, and  
they were in number about four thousand who had not  
been slain.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг илгээгээд тэд Нифайхагийн нутгийн зүг жагсан явахаа үргэлжлүүлэв. Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайха хотод ирснийхээ дараа, тэд Нифайха хотын дэргэдэх тэр Нифайхагийн талд майхнуудаа босгосон болой.

19 Эдүгээ Моронай леменчүүдийг тэдний эсрэг тулалдахаар, уг талд гарч ирээсэй хэмээн хүсч байв; гэвч леменчүүд, тэдний үлэмж агуу зоригийг мэдэж байсан учир, мөн тэдний тооны ихийг болгоосон учир, тиймийн тул тэд тэдний эсрэг гарч ирж зүрхэлсэнгүй; тиймийн тул тэд тэр өдөр тулалдахаар ирсэнгүй.

20 Мөн шөнө болоход, Моронай шөнийн харанхуйд урагшлан, мөн хотын аль хэсэгт нь леменчүүд их цэрэгтэйгээ буудалласныг тагнахаар хэрмийн орой дээр гарав.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд орцны дэргэд дорно хэсэгт нь байв; мөн тэд бүгд унтаж байв. Мөн эдүгээ Моронай их цэрэгтээ буцаж, мөн тэднийг хэрмийн орой дээрээс дотор тал уруу нь хэрмээс доош буулгаж болохын тулд бат бөх олснууд болон шатнуудыг яаравчлан бэлтгэх болгов.

22 Мөнхүү улиран тохиох дор Моронай өөрийн хүмүүсийг урагш давшин мөн хэрмийн орой дээр гарч, мөн леменчүүд их цэрэгтэйгээ буудаллаагүй хотын доторх тэр хэсэгт, тийм ээ, бүр баруун талд өөрсдийгөө буулгах болгов.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд, бат бөх олс мөн шатныхаа тусламжтайгаар шөнөөр хотод буулгагдаж; тийн өглөө болоход тэд бүгд хотын хэрмэн дотор байв.

24 Мөн эдүгээ, леменчүүд сэрж мөн Моронайн их цэргийг хэрмэн дотор байгааг хараад, тэд үлэмж айцгааж, үүний хэрээр тэд гарцаар зугтаж гарав.

25 Мөн эдүгээ Моронай өөрийнх нь өмнө тэдний зугтаж буйг хараад, тэрээр өөрийн хүмүүсийг тэдний эсрэг урагш давшиж, мөн олныг нь алж мөн бусад олныг нь бүслэн, мөн тэднийг олзлогдогсод болгон баривчлах болгов; мөн тэдний үлдсэн нь тэнгисийн эргийн ойролцоох Моронайн нутаг тийш зугтав.

And it came to pass that when they had sent them away they pursued their march towards the land of Nephihah. And it came to pass that when they had come to the city of Nephihah, they did pitch their tents in the plains of Nephihah, which is near the city of Nephihah.

Now Moroni was desirous that the Lamanites should come out to battle against them, upon the plains; but the Lamanites, knowing of their exceedingly great courage, and beholding the greatness of their numbers, therefore they durst not come out against them; therefore they did not come to battle in that day.

And when the night came, Moroni went forth in the darkness of the night, and came upon the top of the wall to spy out in what part of the city the Lamanites did camp with their army.

And it came to pass that they were on the east, by the entrance; and they were all asleep. And now Moroni returned to his army, and caused that they should prepare in haste strong cords and ladders, to be let down from the top of the wall into the inner part of the wall.

And it came to pass that Moroni caused that his men should march forth and come upon the top of the wall, and let themselves down into that part of the city, yea, even on the west, where the Lamanites did not camp with their armies.

And it came to pass that they were all let down into the city by night, by the means of their strong cords and their ladders; thus when the morning came they were all within the walls of the city.

And now, when the Lamanites awoke and saw that the armies of Moroni were within the walls, they were affrighted exceedingly, insomuch that they did flee out by the pass.

And now when Moroni saw that they were fleeing before him, he did cause that his men should march forth against them, and slew many, and surrounded many others, and took them prisoners; and the remainder of them fled into the land of Moroni, which was in the borders by the seashore.

26 Ийн Моронай Пахоран нар Нифайха хотыг нэг ч бодгалийн гарзгүйгээр эзэмшлээ олж авав; мөн леменчүүдээс алагдсан нь олон байв.

27 Эдүгээ улиран тохиох дор олзлогдсон леменчүүдээс олон нь Аммоны хүмүүстэй нэгдэж, чөлөөт хүмүүс болох хүсэлтэй байв.

28 Мөнхүү улиран тохиох дор хүссэн болгонд, өөрсдийнх нь хүслийн дагуу байх нь тэдэнд зөвшөөрөгдсөн ажээ.

29 Тиймийн тул, леменчүүдийн бүх олзлогдогсод Аммоны хүмүүстэй нэгдэж, мөн газар боловсруулж, төрөл бүрийн үр тариа, мөн янз бүрийн бог болон бод мал өсгөж үлэмж хөдөлмөрлөж эхлэв; мөн ийн нифайчууд нэгэн их ачааллаас салав; тийм ээ, үүний хэрээр тэд леменчүүдийн бүх олзлогдогсдыг харгалзах хариуцлагаас ангижирсан ажгуу.

30 Эдүгээ улиран тохиох дор Моронай, Нифайха хотыг эзэмшилдээ авсныхаа дараа, леменчүүдийн их цэргийг үлэмж цөөрүүлэн, олныг олзолсныхоо дараа, мөн Моронайн их цэргийг үлэмж хүчирхэгжүүлсэн тэрхүү олзлогдсон нифайчуудаас олныг буцаан авсныхаа дараа; тиймийн тул Моронай Нифайхагийн нутгаас Лихайн нутаг тийш одов.

31 Мөнхүү улиран тохиох дор Моронай тэдний эсрэг ирэхийг леменчүүд хараад, тэд дахин айж мөн Моронайн их цэргийн өмнө зугтсан ажээ.

32 Мөнхүү улиран тохиох дор Моронай болон түүний их цэрэг тэднийг хотоос хотод, тэднийг Лихай Тианкум нартай тулгарах хүртэл мөрдөн хөөв; мөн леменчүүд бүр тэнгисийн эргийн дэргэдэх хил хүртэл уруудан, тэд Моронайн нутагт ирэх хүртлээ Лихай Тианкум нараас зугтав.

33 Мөн леменчүүдийн их цэрэг бүгд нэгдэн цуглуулагдсан байв, үүний хэрээр тэд Моронайн нутагт бүгд нэг хэсэг байв. Эдүгээ Амморон, леменчүүдийн хаан, түүнчлэн тэдэнтэй хамт байлаа.

Thus had Moroni and Pahoran obtained the possession of the city of Nephiah without the loss of one soul; and there were many of the Lamanites who were slain.

Now it came to pass that many of the Lamanites that were prisoners were desirous to join the people of Ammon and become a free people.

And it came to pass that as many as were desirous, unto them it was granted according to their desires.

Therefore, all the prisoners of the Lamanites did join the people of Ammon, and did begin to labor exceedingly, tilling the ground, raising all manner of grain, and flocks and herds of every kind; and thus were the Nephites relieved from a great burden; yea, insomuch that they were relieved from all the prisoners of the Lamanites.

Now it came to pass that Moroni, after he had obtained possession of the city of Nephiah, having taken many prisoners, which did reduce the armies of the Lamanites exceedingly, and having regained many of the Nephites who had been taken prisoners, which did strengthen the army of Moroni exceedingly; therefore Moroni went forth from the land of Nephiah to the land of Lehi.

And it came to pass that when the Lamanites saw that Moroni was coming against them, they were again frightened and fled before the army of Moroni.

And it came to pass that Moroni and his army did pursue them from city to city, until they were met by Lehi and Teancum; and the Lamanites fled from Lehi and Teancum, even down upon the borders by the seashore, until they came to the land of Moroni.

And the armies of the Lamanites were all gathered together, insomuch that they were all in one body in the land of Moroni. Now Ammoron, the king of the Lamanites, was also with them.

- 34 Мөнхүү улиран тохиох дор Моронай болон Лихай мөн Тианкум нар Моронайн нутгийн хилийн эргэн тойронд их цэрэгтэйгээ буудалласан байв, үүний хэрээр леменчүүд өмнөд аглаг буйдын хилийн, мөн дорнод аглаг буйдын хилийн дээр бүслэгдсэн байв.
- 35 Мөн тийн тэд шөнийг өнгөрөөхөөр буудаллав. Учир нь болгоогтун, нифайчууд мөн түүнчлэн леменчүүд аяныхаа агуу ихийн учир ядарсан байв; тиймийн тул тэд шөнийн цагт Тианкумаас бусад нь ямар нэгэн арга сэдсэнгүй; учир нь тэрээр Амморонд үлэмж ихээр уурлаж байв, учир юун гэвэл ийм их дайн мөн цус урсалт, тийм ээ, мөн ийм их өлсгөлөнгийн шалтгаан болсон тэдний болон леменчүүдийн хоорондох энэ агуу хийгээд үргэлжийн дайны шалтгаан нь Амморон болон түүний ах Амаликая нар хэмээн тэрээр эргэцүүлэн бодсон ажээ.
- 36 Мөнхүү улиран тохиох дор Тианкум уурандаа леменчүүдийн буудалд нэвтрэн орж, мөн хотын хэрэмнээс өөрийгөө буулгасан болой. Мөн тэрээр олс тойгоо, газраас газарт явж, ингэснээр тэр хааныг олов; мөн тэрээр түүний зүг жад шидэж, энэ нь түүний зүрхний ойролцоо зоогдов. Гэвч болгоогтун, хаан үхэхээсээ өмнө зарц нараа сэрээж, үүний хэрээр тэд Тианкумыг мөрдөж, мөн түүнийг алав.
- 37 Эдүгээ улиран тохиох дор Лихай Моронай хоёр Тианкум үхсэнийг мэдээд тэд үлэмж харамсаж байв; учир нь болгоогтун, тэрээр эх орныхоо төлөө эрэлхэгээр байлдсан хүн, тийм ээ, эрх чөлөөнд үнэнч нөхөр байсан ажгуу; мөн тэрээр үлэмж олон зовлонт зүдгүүрүүдийг тэвчсэн бөлгөө. Гэвч болгоогтун, тэрээр нас баржээ, мөн бүх хорвоогийн жамаар оджээ.
- 38 Эдүгээ улиран тохиох дор маргааш нь Моронай жагсан явж, мөн леменчүүдийн дээр ирж, үүний хэрээр тэднийг агуу их аллагаар тэд хөнөөв; мөн тэд уг нутгаас тэднийг гадагш түрэв; мөн тэд зугтаж, бүр тэд нифайчуудын эсрэг тэр үед дахин эргэж ирсэнгүй.
- 39 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин нэгдүгээр он тийн төгсөв; мөн дайнууд, мөн цус урсгалт, бас өлсгөлөн, бас зовлон олон жилийн турш тэдэнд тийн тохиов.

And it came to pass that Moroni and Lehi and Teancum did encamp with their armies round about in the borders of the land of Moroni, insomuch that the Lamanites were encircled about in the borders by the wilderness on the south, and in the borders by the wilderness on the east.

And thus they did encamp for the night. For behold, the Nephites and the Lamanites also were weary because of the greatness of the march; therefore they did not resolve upon any stratagem in the night-time, save it were Teancum; for he was exceedingly angry with Ammoron, insomuch that he considered that Ammoron, and Amalickiah his brother, had been the cause of this great and lasting war between them and the Lamanites, which had been the cause of so much war and bloodshed, yea, and so much famine.

And it came to pass that Teancum in his anger did go forth into the camp of the Lamanites, and did let himself down over the walls of the city. And he went forth with a cord, from place to place, insomuch that he did find the king; and he did cast a javelin at him, which did pierce him near the heart. But behold, the king did awaken his servants before he died, insomuch that they did pursue Teancum, and slew him.

Now it came to pass that when Lehi and Moroni knew that Teancum was dead they were exceedingly sorrowful; for behold, he had been a man who had fought valiantly for his country, yea, a true friend to liberty; and he had suffered very many exceedingly sore afflictions. But behold, he was dead, and had gone the way of all the earth.

Now it came to pass that Moroni marched forth on the morrow, and came upon the Lamanites, insomuch that they did slay them with a great slaughter; and they did drive them out of the land; and they did flee, even that they did not return at that time against the Nephites.

And thus ended the thirty and first year of the reign of the judges over the people of Nephi; and thus they had had wars, and bloodsheds, and famine, and affliction, for the space of many years.

40 Мөн Нифайн хүмүүсийн дунд аллага, зөрчилдөөн, мөн тэрсэлдээн, мөн төрөл бүрийн алдсууд байв; гэсэн хэдий ч зөв шударгыг үйлдэгчдийн төлөө, тийм ээ, зөв шударгыг үйлдэгчдийн залбирлын улмаас, тэд хэлтрүүлэгдсэн юм.

41 Гэвч болгоогтун, нифайчууд болон леменчүүдийн хоорондох дайны үлэмж агуу урт удааны учир олных нь зүрх сэтгэл хатуурчээ, уг дайны үлэмж агуу урт удааны учир бөлгөө; мөн олных нь зүрх сэтгэл зүдгүүрүүдийнхээ учир зөөлөрч, үүний хэрээр тэд Бурханы өмнө өөрсдийгөө бүр даруу байдлын гүнд хүртэл даруусгасан ажээ.

42 Мөнхүү улиран тохиох дор уг нутгийн леменчүүдэд хамгийн ихээр өртөгдөж болох нутгийн тэдгээр хэсгийг хангалттай хүчирхэг болтол нь Моронай бэхлэсний дараагаар, тэрээр Зарахемла хотод эргэж иржээ; мөн түүнчлэн Хиламан өөрийн өв болох нутагтаа буцав; мөн Нифайн хүмүүсийн дунд дахин нэгэнтээ амар амгалан тогтоогдсон ажгуу.

43 Мөн Моронай их цэргийнхээ удирдлагыг, нэрийг нь Моронайха гэх хүүгийнхээ гарт өгөв; мөн тэрээр өөрийн үлдсэн өдрүүдээ амар амгаланд өнгөрөөж болохын тулд албаа дуусган гэртээ харив.

44 Мөн Пахоран шүүлтийн суудалдаа эргэж очсон болой; мөн Хиламан Бурханы үгийг хүмүүст номлох үүргийг өөртөө дахин авчээ; өөрөөр хэлбэл ийм олон дайн мөн зөрчилдөөнүүдийн улмаас сүмд дахин зохицуулалт хийх нь зайлшгүй болсон байв.

45 Тиймийн тулд, Хиламан мөн түүний ах дүүс одож, мөн Бурханы үгийг ихэд хүчтэйгээр тунхаглав, ингэснээр олон хүнд өөрсдийнх нь ёс бусын талаар итгүүлэн, тиймээс тэднийг нүглүүдээ наманчилж мөн Их Эзэн Бурхандаа баптисм хүртэхэд хүргэв.

46 Мөнхүү улиран тохиох дор тэд бүх нутаг даяар Бурханы сүмийг дахин байгуулсан болой.

47 Тийм ээ, мөн хуулийн талаар зохицуулалтууд хийгдэв. Мөн тэдний шүүгчид, мөн ерөнхий шүүгчид сонгогдов.

48 Мөн Нифайн хүмүүс нутагтаа дахин дэгжиж эхлэв, мөн нутагтаа өнөржиж бас дахин үлэмж хүчирхэг болж эхлэв, мөн тэд үлэмж баян болж эхлэв.

And there had been murders, and contentions, and dissensions, and all manner of iniquity among the people of Nephi; nevertheless for the righteous' sake, yea, because of the prayers of the righteous, they were spared.

But behold, because of the exceedingly great length of the war between the Nephites and the Lamanites many had become hardened, because of the exceedingly great length of the war; and many were softened because of their afflictions, insomuch that they did humble themselves before God, even in the depth of humility.

And it came to pass that after Moroni had fortified those parts of the land which were most exposed to the Lamanites, until they were sufficiently strong, he returned to the city of Zarahemla; and also Helaman returned to the place of his inheritance; and there was once more peace established among the people of Nephi.

And Moroni yielded up the command of his armies into the hands of his son, whose name was Moronihah; and he retired to his own house that he might spend the remainder of his days in peace.

And Pahoran did return to his judgment-seat; and Helaman did take upon him again to preach unto the people the word of God; for because of so many wars and contentions it had become expedient that a regulation should be made again in the church.

Therefore, Helaman and his brethren went forth, and did declare the word of God with much power unto the convincing of many people of their wickedness, which did cause them to repent of their sins and to be baptized unto the Lord their God.

And it came to pass that they did establish again the church of God, throughout all the land.

Yea, and regulations were made concerning the law. And their judges, and their chief judges were chosen.

And the people of Nephi began to prosper again in the land, and began to multiply and to wax exceedingly strong again in the land. And they began to grow exceedingly rich.

49 Гэвч тэдний баялаг, өөрөөр хэлбэл хүч чадал, өөрөөр хэлбэл дэгжил хөгжил байсан хэдий ч, тэд өөрсдийнхөө нүдэнд бардамнан хөөрсөн нь үгүй; бас Их Эзэн Бурханаа дурсан санахдаа ч хойрго байсангүй; харин тэд түүний өмнө өөрсдийгөө үлэмж даруусгасан ажээ.

50 Тийм ээ, Их Эзэн тэдний төлөө ямар агуу зүйлүүд хийснийг, тэрээр тэднийг үхлээс, мөн гав гинжнээс мөн шоронгоос, мөн төрөл бүрийн зүдгүүрүүдээс чөлөөлснийг, мөн тэрээр тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлснийг тэд санаж байв.

51 Мөн тэд Их Эзэн Бурхандаа үргэлж залбирч, үүний хэрээр Их Эзэн тэднийг өөрийн үгийн дагуу адисалсан бөлгөө, иймээс тэд хүчтэй болж мөн уг нутагт дэгжсэн юм.

52 Мөнхүү улиран тохиох дор эдгээр бүх зүйлүүд хийгдэв. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин тавдугаар онд Хиламан нас барав.

But notwithstanding their riches, or their strength, or their prosperity, they were not lifted up in the pride of their eyes; neither were they slow to remember the Lord their God; but they did humble themselves exceedingly before him.

Yea, they did remember how great things the Lord had done for them, that he had delivered them from death, and from bonds, and from prisons, and from all manner of afflictions, and he had delivered them out of the hands of their enemies.

And they did pray unto the Lord their God continually, insomuch that the Lord did bless them, according to his word, so that they did wax strong and prosper in the land.

And it came to pass that all these things were done. And Helaman died, in the thirty and fifth year of the reign of the judges over the people of Nephi.



## Алма 63

- 1 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин зургадугаар оны эхэнд, Алмагаар Хиламанд хүргэгдсэн ариун зүйлүүдийг Шиблон эзэмшилдээ авав.
- 2 Мөн тэр шударга хүн байв, мөн тэрээр Бурханы өмнө зөв шударгаар алхдаг байв; мөн тэр үргэлж сайныг үйлдэхийг, Их Эзэн Бурханыхаа зарлигуудыг дагахыг чармайдаг байв; мөн түүний дүү нь ч бас түүнчлэн буюу.
- 3 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн Моронай нас барав. Мөн шүүгчдийн засаглалын гучин зургадугаар он ийн төгсөв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын гучин долдугаар онд, эрчүүдийн томоохон хэсэг, бүр таван мянга дөрвөн зуун эрс, эхнэр мөн хүүхдүүдийнхээ хамт, Зарахемла нутгаас гарч умардахь нутаг тийш одов.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Хагот, тэрээр үлэмж сониуч хүн байсан учир, тиймийн тул тэрээр одож мөн өөртөө үлэмж том усан онгоцыг, Өгөөмөр нутгийн хил дээр, Эзгүйрэл нутгийн захад барьж мөн өрнөд тэнгист, умард нутагт удирдах тэрхүү нарийн хоолойн дэргэд усанд тавьжээ.
- 6 Мөн болгоогтун, үүнд сууж мөн их хүнс нөөцтэйгээр хөвж одсон нь нифайчуудаас олон байв, мөн түүнчлэн олон эмэгтэйчүүд мөн хүүхдүүд байв; мөн тэд умардыг чиглэн аянаа хөөв. Мөн гучин долдугаар он тийн төгсөв.
- 7 Мөн гучиннайм дахь онд энэ хүн өөр бусад онгоцуудыг барив. Мөн эхний онгоц түүнчлэн эргэж ирэв, мөн өөр олон хүмүүс үүнд оров; мөн түүнчлэн тэд их нөөц хүнс авч мөн умард нутгийг дахин чиглэв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэднээс дахин сураг сонсогдсонгүй. Мөн бид тэднийг тэнгисийн гүнд живсэн буйза хэмээн бодном. Мөнхүү улиран тохиох дор өөр нэг онгоц түүнчлэн хөвж одов; мөн түүний хааш одсоныг бид мэдэх нь үгүй.

## Alma 63

And it came to pass in the commencement of the thirty and sixth year of the reign of the judges over the people of Nephi, that Shiblon took possession of those sacred things which had been delivered unto Helaman by Alma.

And he was a just man, and he did walk uprightly before God; and he did observe to do good continually, to keep the commandments of the Lord his God; and also did his brother.

And it came to pass that Moroni died also. And thus ended the thirty and sixth year of the reign of the judges.

And it came to pass that in the thirty and seventh year of the reign of the judges, there was a large company of men, even to the amount of five thousand and four hundred men, with their wives and their children, departed out of the land of Zarahemla into the land which was northward.

And it came to pass that Hagoth, he being an exceedingly curious man, therefore he went forth and built him an exceedingly large ship, on the borders of the land Bountiful, by the land Desolation, and launched it forth into the west sea, by the narrow neck which led into the land northward.

And behold, there were many of the Nephites who did enter therein and did sail forth with much provisions, and also many women and children; and they took their course northward. And thus ended the thirty and seventh year.

And in the thirty and eighth year, this man built other ships. And the first ship did also return, and many more people did enter into it; and they also took much provisions, and set out again to the land northward.

And it came to pass that they were never heard of more. And we suppose that they were drowned in the depths of the sea. And it came to pass that one other ship also did sail forth; and whither she did go we know not.

- 9 Мөнхүү улиран тохиох дор энэ онд умард нутаг тийш одсон олон хүмүүс байв. Мөн гучин найм дахь он тийн төгсөв.
- 10 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын гучин есдүгээр онд, түүнчлэн Шиблон нас барж, мөн Кориантон тэр нутаг тийш одсон хүмүүст нөөц хүнс хүргэхээр умард нутаг тийш усан онгоцор одсон бөлгөө.
- 11 Тиймийн тул нас барахынхаа өмнө, эцгийнхээ нэрээр нэрлэгдсэн, Хиламаны хүүд, Хиламан гэж нэрлэгдсэн түүнд тэдгээр ариун нандин зүйлийг шилжүүлэх нь Шиблоны хувьд зайлшгүй болов.
- 12 Эдүгээ болгоогтун, Хиламаны эзэмшилд байсан тэдгээр бүх сийлбэрүүд бичиглэгдэж мөн Алмагаар очих ёсгүй хэмээн зарлиг болгогдсон хэсгүүдээс буцад нь, бүх нутаг даяар хүмүүний үрсийн дунд илгээгдэв.
- 13 Гэсэн хэдий ч, эдгээр зүйлүүд нь ариун нандин хэвээр хадгалагдаж мөн нэг үеэс нөгөөд доош гардуулагдах ёстой байв; тиймийн тул, энэ онд, тэдгээр нь Шиблоныг нас барахын өмнө Хиламанд шилжүүлэгдсэн байлаа.
- 14 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн энэ онд леменчүүд дээр очсон зарим тэрслэгчид байв; мөн тэд нифайчуудын эсрэг уур уцаарт дахин өдөөн хатгагдав.
- 15 Мөн түүнчлэн мөнхүү онд тэд олон тооны цэрэгтэйгээр Моронайхагийн хүмүүсийн эсрэг, өөрөөр хэлбэл Моронайхагийн их цэргийн эсрэг дайтахаар ирэв, ингэхдээ үлэмж их хохирол хүлээсээр, тэд ялагдан мөн нутгийнхаа зүг дахин ухарчээ.
- 16 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын гучин есдүгээр он тийн төгсөв.
- 17 Мөн Алмагийн, мөн түүний хүү Хиламаны, мөн түүнчлэн түүний хүү асан Шиблоны шастир ийн төгсөв.

And it came to pass that in this year there were many people who went forth into the land northward. And thus ended the thirty and eighth year.

And it came to pass in the thirty and ninth year of the reign of the judges, Shiblōn died also, and Corianton had gone forth to the land northward in a ship, to carry forth provisions unto the people who had gone forth into that land.

Therefore it became expedient for Shiblōn to confer those sacred things, before his death, upon the son of Helaman, who was called Helaman, being called after the name of his father.

Now behold, all those engravings which were in the possession of Helaman were written and sent forth among the children of men throughout all the land, save it were those parts which had been commanded by Alma should not go forth.

Nevertheless, these things were to be kept sacred, and handed down from one generation to another; therefore, in this year, they had been conferred upon Helaman, before the death of Shiblōn.

And it came to pass also in this year that there were some dissenters who had gone forth unto the Lamanites; and they were stirred up again to anger against the Nephites.

And also in this same year they came down with a numerous army to war against the people of Moronihah, or against the army of Moronihah, in the which they were beaten and driven back again to their own lands, suffering great loss.

And thus ended the thirty and ninth year of the reign of the judges over the people of Nephi.

And thus ended the account of Alma, and Helaman his son, and also Shiblōn, who was his son.

# ХИЛАМАНЫ НОМ

*Нифайчуудын шастир оршвой. Тэдний дайн мөн зөрчилдөөнүүд, мөн тэдний тэрсэлдээнүүд оршвой. Мөн түүнчлэн Хиламаны хүү асан Хиламаны цэдгүүдийн дагуу, мөн түүнчлэн түүний хөвгүүдийн цэдгүүдийн дагуу, Христийн ирэлтээс өмнөх үеэс, бүр Христийн ирэлтийг хүртэлх олон ариун бошиглогчдын бошиглолууд оршвой. Мөн түүнчлэн леменчүүдээс олон нь хөрвүүлэгдэв. Тэдний хөрвүүлгийн тухай шастир оршвой. Бүр Христийн ирэлтийг хүртэлх, Хиламаны ном хэмээн нэрлэгдсэн тэр Хиламан мөн түүний хөвгүүдийн цэдгийн дагуу леменчүүдийн зөв шударга явдал, нифайчуудын ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн тухай, мөн энэ мэтчилэнгийн шастир оршвой.*

## Хиламан 1

- 1 Мөн эдүгээ болгоогтун, улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын дөчдүгээр оны эхэнд, нифайчуудын ардын дунд ноцтой бэрхшээл эхлэв.
- 2 Учир нь болгоогтун, Пахоран нас барж, мөн бүх хорвоогийн жамаар одов; тиймийн тул Пахораны хөвгүүд асан, ах дүүсийн дунд хэн шүүлтийн суудлыг эзэлбэл зохих талаар ноцтой зөрчилдөөн бий болж эхлэв.
- 3 Эдүгээ шүүлтийн суудлын төлөө тэмцэлдсэн мөн хүмүүсийг тэмцэлдэхэд хүргэсэн тэдний нэр нь эдгээр болой: Пахоран, Пейнкай болон Пекүменаи.
- 4 Эдүгээ эдгээр нь Пахораны бүх хөвгүүд бус байв (учир нь түүнд олон байжээ), гэвч эд бол шүүлтийн суудлын төлөө тэмцэлдсэн тэд байв; тиймийн тул, тэд хүмүүсийн дунд гурван хэсгийг бий болгов.
- 5 Гэсэн хэдий ч, улиран тохиох дор Пахоран хүмүүсийн саналаар Нифайн хүмүүсийн дээрх ерөнхий шүүгч мөн засаглагчаар томилогдов.
- 6 Мөнхүү улиран тохиох дор Пекүменаи, тэрээр шүүлтийн суудлыг авч чадахгүйгээ хараад, тэрээр хүмүүсийн саналтай нэгдсэн ажээ.

# The Book of Helaman

*An account of the Nephites. Their wars and contentions, and their dissensions. And also the prophecies of many holy prophets, before the coming of Christ, according to the records of Helaman, who was the son of Helaman, and also according to the records of his sons, even down to the coming of Christ. And also many of the Lamanites are converted. An account of their conversion. An account of the righteousness of the Lamanites, and the wickedness and abominations of the Nephites, according to the record of Helaman and his sons, even down to the coming of Christ, which is called the book of Helaman, and so forth.*

## Helaman 1

And now behold, it came to pass in the commencement of the fortieth year of the reign of the judges over the people of Nephi, there began to be a serious difficulty among the people of the Nephites.

For behold, Pahoran had died, and gone the way of all the earth; therefore there began to be a serious contention concerning who should have the judgment-seat among the brethren, who were the sons of Pahoran.

Now these are their names who did contend for the judgment-seat, who did also cause the people to contend: Pahoran, Paanchi, and Pacumeni.

Now these are not all the sons of Pahoran (for he had many), but these are they who did contend for the judgment-seat; therefore, they did cause three divisions among the people.

Nevertheless, it came to pass that Pahoran was appointed by the voice of the people to be chief judge and a governor over the people of Nephi.

And it came to pass that Pacumeni, when he saw that he could not obtain the judgment-seat, he did unite with the voice of the people.

- 7 Гэвч болгоогтун, Пейнкай болон түүнийг өөрсдийн захирагч болоосой хэмээх хүсэлтэй хүмүүсийн хэсэг нь үлэмж хилэгнэж байв; тиймийн тул, тэрээр ах дүүсийнхээ эсрэг тэдгээр хүмүүсийг эсэргүүцэлд босгохоор зусардах гэж байв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэр үүнийг бараг л хийх гэж байхад, болгоогтун, тэр баривчлагдав, мөн хүмүүсийн саналын дагуу шүүгдэн, мөн үхлийн ял тулгагдсан аж; учир нь тэрээр эсэргүүцэлд босож мөн хүмүүсийн чөлөөт байдлыг устгахыг эрэлхийлсэн ажээ.
- 9 Эдүгээ түүнийг өөрсдийн захирагч байхыг хүссэн тэдгээр хүмүүс тэрээр үхлийн ял хүлээхийг хараад, тиймийн тул тэд ууртай байв, мөн болгоогтун, тэд Кишкумен гэгч нэгнийг, бүр Пахораны шүүлтийн суудал уруу илгээж, мөн Пахораныг шүүлтийн суудал дээрээ сууж байхад нь түүнийг хөнөөв.
- 10 Мөн тэрээр Пахораны зарц нарт мөрдөн хөөгдөв; гэвч болгоогтун, Кишкумений зугталт ямар ч хүн түүнийг гүйцэж чадахааргүй тийм хурдан байжээ.
- 11 Мөн тэрээр өөрийг нь илгээсэн тэдэнд очив, мөн тэд Пахораныг Кишкумен алсныг хэнд ч хэлэхгүй хэмээцгээн өөрсдийн үүрдийн Бий Болгогчоороо тангараглан, тийм ээ, тэд бүгд гэрээнд оров.
- 12 Тиймийн тул, Кишкумен Нифайн хүмүүсийн дунд мэдэгдсэнгүй, учир нь тэрээр Пахораныг алах үедээ зүсээ хувиргасан байжээ. Мөн Кишкумен болон түүнтэй гэрээ хийж үгсэн түүнтэй хуйвалдагсад, тэд бүгд олодох боломжгүй тийм байдлаар өөрсдөө хүмүүсийн дунд хутгалдав; гэвч олдсон бүгд нь үхлээр яллагдав.
- 13 Мөн эдүгээ болгоогтун, хүмүүсийн дээрх захирагч бөгөөд ерөнхий шүүгч байхаар, ах Пахораныхоо оронд засаглахаар хүмүүсийн саналын дагуу Пекүменай тохоогдов; мөн энэ нь түүний эрхийн дагуу байв. Мөн энэ бүхэн шүүгчдийн засаглалын дөч дүгээр онд үйлдэгдэж; мөн тус он төгсгөл болов.
- 14 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын дөчин нэгдүгээр онд, леменчүүд тоолшгүй олон эрстэй их цэргийг нэгтгэн цутлуулж, мөн тэднийг сэлмээр, мөн илдээр мөн нум, мөн сумнууд, мөн толгойн дуулга, мөн цээжний хуягаар, мөн зүйл бүрийн бүх төрлийн хамгаалалтаар зэвсэглэсэн байв.

But behold, Paanchi, and that part of the people that were desirous that he should be their governor, was exceedingly wroth; therefore, he was about to flatter away those people to rise up in rebellion against their brethren.

And it came to pass as he was about to do this, behold, he was taken, and was tried according to the voice of the people, and condemned unto death; for he had raised up in rebellion and sought to destroy the liberty of the people.

Now when those people who were desirous that he should be their governor saw that he was condemned unto death, therefore they were angry, and behold, they sent forth one Kishkumen, even to the judgment-seat of Pahoran, and murdered Pahoran as he sat upon the judgment-seat.

And he was pursued by the servants of Pahoran; but behold, so speedy was the flight of Kishkumen that no man could overtake him.

And he went unto those that sent him, and they all entered into a covenant, yea, swearing by their everlasting Maker, that they would tell no man that Kishkumen had murdered Pahoran.

Therefore, Kishkumen was not known among the people of Nephi, for he was in disguise at the time that he murdered Pahoran. And Kishkumen and his band, who had covenanted with him, did mingle themselves among the people, in a manner that they all could not be found; but as many as were found were condemned unto death.

And now behold, Pacumeni was appointed, according to the voice of the people, to be a chief judge and a governor over the people, to reign in the stead of his brother Pahoran; and it was according to his right. And all this was done in the fortieth year of the reign of the judges; and it had an end.

And it came to pass in the forty and first year of the reign of the judges, that the Lamanites had gathered together an innumerable army of men, and armed them with swords, and with cimeters and with bows, and with arrows, and with head-plates, and with breast-plates, and with all manner of shields of every kind.

15 Мөн тэд нифайчуудын эсрэг дайн өдөөж болохын тулд дахин уруудаж ирэв. Мөн тэд Кориантумр гэдэг нэртэй эрээр удирдуулсан байв; мөн тэрбээр Зарахемлагийн удам байв; мөн тэрээр нифайчуудын дундаас тэрслэгч байв; тэрбээр том биетэй мөн чадалтай эр байв.

16 Тиймийн тул, Аммораны хүү асан, нэрийг нь Тубалоф гэдэг байсан леменчүүдийн хаан, Кориантумрыг чадалтай хүн байсан учраас нифайчуудын эсрэг өөрийн хүч чадал мөн түүнчлэн их мэргэн ухаанаараа зогсож чадна хэмээн, үүний хэрээр тэрээр түүнийг илгээснээрээ нифайчуудын дээр эрх мэдлийг олно хэмээн бодоод—

17 Тиймийн тул тэр тэднийг уурлуулахаар өдөөн хатгаж, мөн тэрээр их цэргээ нэгтгэн цуглуулж, мөн тэрээр Кориантумрыг тэдний удирдагч байхаар тохоож, мөн тэднийг Зарахемлагийн нутаг уруу нифайчуудын эсрэг байлдахаар давшин очих болгов.

18 Мөнхүү улиран тохиох дор засгийн газар дахь тийм их зөрчил мөн тийм их бэрхшээлийн учир, тэд Зарахемлагийн нутагт хангалттай харуулуудыг байлгасангүй; учир нь агуу их хот Зарахемлаг дайрахаар тэдний нутгуудын цээжинд леменчүүд ирж зүрхлэхгүй гэж тэд бодсон байв.

19 Гэвч улиран тохиох дор Кориантумр өөрийн олон тоотой цэргийнхээ тэргүүнд давшин алхаж байв, мөн уг хотын оршин суугчдын дээр ирэв, мөн тэдний алхах нь үлэмж хурдан байсан тул их цэргээ нэгтгэн цуглуулах цаг нифайчуудад байсангүй.

20 Тиймийн тул Кориантумр хотын хаалганы дэргэдэх харуулуудыг цавчиж, мөн бүх их цэрэгтэйгээ хотод давшин орж, мөн тэд өөрсдийг нь эсэргүүцсэн хүн бүрийг хөнөөж, үүний хэрээр тэд бүхэл хотыг эзэмшилдээ авсан ажгуу.

21 Мөнхүү улиран тохиох дор ерөнхий шүүгч асан Пекүменай, Кориантумрын өмнө, бүр хотын хэргийг хүртэл зугтав. Мөнхүү улиран тохиох дор Кориантумр түүнийг ханатай хавсран цохиж, үүний хэрээр тэр үхэв. Мөн Пекүменайн өдрүүд тийн төгсөв.

And they came down again that they might pitch battle against the Nephites. And they were led by a man whose name was Coriantumr; and he was a descendant of Zarahemla; and he was a dissenter from among the Nephites; and he was a large and a mighty man.

Therefore, the king of the Lamanites, whose name was Tubaloth, who was the son of Ammoron, supposing that Coriantumr, being a mighty man, could stand against the Nephites, with his strength and also with his great wisdom, insomuch that by sending him forth he should gain power over the Nephites—

Therefore he did stir them up to anger, and he did gather together his armies, and he did appoint Coriantumr to be their leader, and did cause that they should march down to the land of Zarahemla to battle against the Nephites.

And it came to pass that because of so much contention and so much difficulty in the government, that they had not kept sufficient guards in the land of Zarahemla; for they had supposed that the Lamanites durst not come into the heart of their lands to attack that great city Zarahemla.

But it came to pass that Coriantumr did march forth at the head of his numerous host, and came upon the inhabitants of the city, and their march was with such exceedingly great speed that there was no time for the Nephites to gather together their armies.

Therefore Coriantumr did cut down the watch by the entrance of the city, and did march forth with his whole army into the city, and they did slay every one who did oppose them, insomuch that they did take possession of the whole city.

And it came to pass that Pacumeni, who was the chief judge, did flee before Coriantumr, even to the walls of the city. And it came to pass that Coriantumr did smite him against the wall, insomuch that he died. And thus ended the days of Pacumeni.

- 22 Мөн эдүгээ Кориантумр Зарахемла хотыг эзэмшилдээ авснаа хараад мөн нифайчууд тэдний өмнө зугтаж, мөн алагдаж, мөн баривчлагдаж, мөн шоронд хаягдаж байсныг, мөн тэрээр бүх нутгийн хамгийн баг бөх хориглолтыг эзэмшилдээ олж авснаа хараад, түүний зүрх сэтгэл зоригжин үүний улмаас тэрээр бүх нутгийн эсрэг явах гэж байв.
- 23 Мөн эдүгээ тэрээр Зарахемлагийн нутагт үлдсэнгүй, харин тэрээр томоохон их цэргийн хамт, бүр Өгөөмөр хотыг чиглэн давшин алхсан болой; учир нь тэрээр уг нутгийн умард хэсгүүдийг эзлэн авч болохын тулд урагшлан явж мөн илдний хүчээр өмнөө зам гаргах нь түүний хатуу шийдвэр байв.
- 24 Мөнхүү, тэдний хамгийн их хүч нутгийн төвд байсан хэмээн бодоод, тиймийн тул тэдэнд жижиг хэсгүүдээс бусдаар бол нэгдэн цуглах цагийг өгөлгүйгээр тэр урагш давшив; мөн энэ маягаар тэд тэдний дээр бууж мөн тэднийг газарт хиаруулан унагав.
- 25 Гэвч болгоогтун, алагдсан нифайчуудын тоо их олон байсан хэдий ч, уг нутгийн төв дундуурх Кориантумрын энэ давшилт тэдний дээр агуу давуу байдалтай байх боломжийг Моронайхад өглөө.
- 26 Учир нь болгоогтун, леменчүүд уг нутгийн төвд орж ирж зүрхлэхгүй, харин тэд урьд нь тэгж байснаа адил хилийн ойролцоох хотуудад довтолно хэмээн Моронайха бодсон байв; тиймийн тул Моронайха хүчирхэг их цэргээ хилийн ойролцоох хэсгүүдийг хадгалан хамгаалуулахаар болгосон байлаа.
- 27 Гэвч болгоогтун, леменчүүд түүний хүслийн дагуу айсангүй, харин тэд уг нутгийн төвд орж ирэн, мөн нийслэл хот Зарахемла хотыг авав, мөн хүмүүсийг, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдийг аль алиныг нь их аллагаар хөнөөсөөр, олон хот мөн олон хориглолтыг эзэмшилдээ авсаар уг нутгийн хамгийн гол чухал хэсгүүдийн дундуур давшин явж байлаа.
- 28 Гэвч Моронайха үүнийг олж мэдээд, тэднийг Өгөөмөр нутагт ирэхээс нь өмнө тэрээр Лихайг их цэргийн хамт тэднийг амдуулахаар тойруу замаар тэр даруй илгээв.

And now when Coriantumr saw that he was in possession of the city of Zarahemla, and saw that the Nephites had fled before them, and were slain, and were taken, and were cast into prison, and that he had obtained the possession of the strongest hold in all the land, his heart took courage insomuch that he was about to go forth against all the land.

And now he did not tarry in the land of Zarahemla, but he did march forth with a large army, even towards the city of Bountiful; for it was his determination to go forth and cut his way through with the sword, that he might obtain the north parts of the land.

And, supposing that their greatest strength was in the center of the land, therefore he did march forth, giving them no time to assemble themselves together save it were in small bodies; and in this manner they did fall upon them and cut them down to the earth.

But behold, this march of Coriantumr through the center of the land gave Moronihah great advantage over them, notwithstanding the greatness of the number of the Nephites who were slain.

For behold, Moronihah had supposed that the Lamanites durst not come into the center of the land, but that they would attack the cities round about in the borders as they had hitherto done; therefore Moronihah had caused that their strong armies should maintain those parts round about by the borders.

But behold, the Lamanites were not frightened according to his desire, but they had come into the center of the land, and had taken the capital city which was the city of Zarahemla, and were marching through the most capital parts of the land, slaying the people with a great slaughter, both men, women, and children, taking possession of many cities and of many strongholds.

But when Moronihah had discovered this, he immediately sent forth Lehi with an army round about to head them before they should come to the land Bountiful.

- 29 Мөн тэрээр тийн үйлдэв; мөн тэрээр тэднийг Өгөөмөр нутагт ирэхээс нь өмнө тэднийг амдан то-  
сов, мөн тэдэнтэй тулалдаж, үүний хэрээр тэд  
Зарахемлагийн нутгийн зүг гэдрэг ухарч эхлэв.
- 30 Мөнхүү улиран тохиох дор Моронайха тэдний ух-  
ралтад тэднийг амдаж, мөн тэдэнтэй тулалдаж, үү-  
ний хэрээр энэ нь үлэмжийн цуст тулаан болов;  
тийм ээ, олон нь алагдав, мөн алагдсан тэдний дунд  
Кориантумр түүнчлэн байв.
- 31 Мөн эдүгээ, болгоогтун, леменчүүд хаашаа ч,  
умардад ч, бас өмнөдөд ч, бас дорнодод ч, бас өрнө-  
дөд ч ухрах замгүй байв, учир нь тэд тал бүрээсээ ни-  
файчуудаар бүслэгдэв.
- 32 Мөн тийн Кориантумр нифайчуудын дунд лемен-  
чүүдийг оруулсан байж, үүний хэрээр тэд нифайчуу-  
дын хүчинд автаж, мөн тэрээр өөрөө алагдав, мөн  
леменчүүд өөрсдийгөө нифайчуудын гарт өгчээ.
- 33 Мөнхүү улиран тохиох дор Зарахемла хотыг  
Моронайха эзэмшилдээ буцаан авч, мөн олзлогдог-  
сод болгосон леменчүүдийг амар тайвнаар уг нутгаас  
гаргах болгов.
- 34 Мөн шүүгчдийн засаглалын дөчин нэгдүгээр он  
ийн төгсөв.

And thus he did; and he did head them before they  
came to the land Bountiful, and gave unto them battle,  
insomuch that they began to retreat back towards the  
land of Zarahemla.

And it came to pass that Moronihah did head them  
in their retreat, and did give unto them battle, inso-  
much that it became an exceedingly bloody battle; yea,  
many were slain, and among the number who were  
slain Coriantumr was also found.

And now, behold, the Lamanites could not retreat ei-  
ther way, neither on the north, nor on the south, nor on  
the east, nor on the west, for they were surrounded on  
every hand by the Nephites.

And thus had Coriantumr plunged the Lamanites  
into the midst of the Nephites, insomuch that they  
were in the power of the Nephites, and he himself was  
slain, and the Lamanites did yield themselves into the  
hands of the Nephites.

And it came to pass that Moronihah took possession  
of the city of Zarahemla again, and caused that the  
Lamanites who had been taken prisoners should depart  
out of the land in peace.

And thus ended the forty and first year of the reign of  
the judges.

## Хиламан 2

- 1 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын дөчин хоёрдугаар онд, нифайчууд болон леменчүүдийн хооронд Моронайха дахин амар амгаланг тогтоосны дараа, болгоогтун шүүлтийн суудлыг эзлэх хэн ч үгүй байв; тиймийн тул шүүлтийн суудлыг хэн эзэлбэл зохих талаар хүмүүсийн дунд дахин зөрчилдөөн гарч эхлэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Хиламаны хүү асан тэр Хиламан, хүмүүсийн саналаар, шүүлтийн суудлыг эзлэхээр тохоогдов.
- 3 Гэвч болгоогтун, Пахораныг алсан Кишкумен, түүнчлэн Хиламаныг устгахаар отон хүлээсэн ажгуу; мөн тэр түүний ёс бусыг хэн ч мэдэхгүй хэмээх гэрээнд орсон бүлэглэлийнхнээрээ дэмжигдэв.
- 4 Учир нь, олон үг ярихдаа, мөн түүнчлэн аллагын болон дээрмийн нууц ажлыг удирдан явуулах башир аргадаа үлэмж мэргэшсэн Гадантон гэгч нэгэн байв; тиймийн тул тэрбээр Кишкуменийн бүлэглэлийн удирдагч болов.
- 5 Тиймийн тул хэрэв тэд өөрийг нь шүүлтийн суудалд суулгах аваас тэрээр бүлэглэлд нь харьяалагдсан тэд хүмүүсийн дунд хүч болон эрх мэдэл бүхий албанд тохоогдохыг тэдэнд зөвшөөрнө хэмээн тэрээр тэднийг, мөн түүнчлэн Кишкуменийг зусардав; тиймийн тул Кишкумен Хиламаныг устгахыг эрэлхийлэв.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Хиламаныг устгахаар шүүлтийн суудлын зүг урагшлан явах зуур, болгоогтун Хиламаны зарц нарын нэг нь, шөнөөр гадуур байж байгаад, мөн зүсээ хувиргаснаар, Хиламаныг устгахаар энэ бүлэглэлээр зохиогдсон төлөвлөгөөний тухай мэдэж авчээ—
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Кишкументэй тааралдахад, мөн тэрээр түүнд нэгэн нууц дохио өгч; тиймийн тул Кишкумен түүнд өөрийн хүсэл зорилгоо мэдүүлж, өөрөө Хиламаныг алж болохын тулд шүүлтийн суудлын зүг өөрийг нь дагуулахыг түүнээс хүсэв.

## Helaman 2

And it came to pass in the forty and second year of the reign of the judges, after Moronihah had established again peace between the Nephites and the Lamanites, behold there was no one to fill the judgment-seat; therefore there began to be a contention again among the people concerning who should fill the judgment-seat.

And it came to pass that Helaman, who was the son of Helaman, was appointed to fill the judgment-seat, by the voice of the people.

But behold, Kishkumen, who had murdered Pahoran, did lay wait to destroy Helaman also; and he was upheld by his band, who had entered into a covenant that no one should know his wickedness.

For there was one Gadianton, who was exceedingly expert in many words, and also in his craft, to carry on the secret work of murder and of robbery; therefore he became the leader of the band of Kishkumen.

Therefore he did flatter them, and also Kishkumen, that if they would place him in the judgment-seat he would grant unto those who belonged to his band that they should be placed in power and authority among the people; therefore Kishkumen sought to destroy Helaman.

And it came to pass as he went forth towards the judgment-seat to destroy Helaman, behold one of the servants of Helaman, having been out by night, and having obtained, through disguise, a knowledge of those plans which had been laid by this band to destroy Helaman—

And it came to pass that he met Kishkumen, and he gave unto him a sign; therefore Kishkumen made known unto him the object of his desire, desiring that he would conduct him to the judgment-seat that he might murder Helaman.



- 8 Мөн Кишкуменийн бүх зүрх сэтгэлийг, мөн алах нь хэрхэн түүний зорилго байгааг, мөн түүнчлэн алах, мөн дээрэмдэх, мөн хүчийг олох нь түүний бүлэглэлд харьяалагдсан тэд бүгдийн зорилт байсныг (мөн энэ нь тэдний нууц төлөвлөгөө, мөн тэдний хуйвалдаан байв) Хиламаны зарц олж мэдээд, Хиламаны зарц Кишкуменд хэлэв: Шүүлтийн суудлын зүг явцгаая.
- 9 Эдүгээ энэ нь Кишкуменийг үлэмж баярлуулж, учир нь тэрээр төлөвлөгөөгөө гүйцээнэ хэмээн бодсон болой; гэвч болгоогтун, тэд шүүлтийн суудлын зүг явж байх үед, Хиламаны зарц Кишкуменийг, бүр зүрхэнд нь хутгалав, иймээс тэрээр дуу гаргалгүйгээр үхэтхийн унав. Мөн тэр гүйж мөн Хиламанд өөрийн бүх харсан, мөн сонссон, мөн хийсэн зүйлүүдээ хэлэв.
- 10 Мөнхүү улиран тохиох дор тэд хуулийн дагуу цаазлагдаж болохын тулд, дээрэмчид мөн нууц алуурчдын энэ бүлэглэлийнхнийг баривчлуулахаар Хиламан хүмүүсийг илгээв.
- 11 Гэвч болгоогтун, Кишкуменийн эргэж ирээгүйг Гадантон олж мэдээд тэрээр устгагдах вий хэмээн айв; тиймийн тул тэрээр өөрийн бүлэглэлийнхнийг өөрийгөө дагах болгов. Мөн тэд уг нутгаас гарч, нууц замаар, аглаг буйд тийш зугтав; мөн Хиламан тийн тэднийг баривчлуулахаар хүмүүсийг илгээхэд тэд хаанаас ч олдсонгүй.
- 12 Мөн энэ Гадантоны тухайд хожим илүү ихээр яригдах болно. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын дөчин хоёр дахь он ийн төгсөв.
- 13 Мөн болгоогтун, энэ номын төгсгөлд энэхүү Гадантон Нифайн хүмүүсийн ялагдлыг, тийм ээ, бараг бүрэн устгалыг нь авчирсныг та нар харах болно.
- 14 Болгоогтун би Хиламаны номын төгсгөлийг бус, харин өөрийн бичиглэсэн тэр бүх шастираа би тэндээс авсан түүний буюу Нифайн номны төгсгөлийг хэлж байна.

And when the servant of Helaman had known all the heart of Kishkumen, and how that it was his object to murder, and also that it was the object of all those who belonged to his band to murder, and to rob, and to gain power, (and this was their secret plan, and their combination) the servant of Helaman said unto Kishkumen: Let us go forth unto the judgment-seat.

Now this did please Kishkumen exceedingly, for he did suppose that he should accomplish his design; but behold, the servant of Helaman, as they were going forth unto the judgment-seat, did stab Kishkumen even to the heart, that he fell dead without a groan. And he ran and told Helaman all the things which he had seen, and heard, and done.

And it came to pass that Helaman did send forth to take this band of robbers and secret murderers, that they might be executed according to the law.

But behold, when Gadianton had found that Kishkumen did not return he feared lest that he should be destroyed; therefore he caused that his band should follow him. And they took their flight out of the land, by a secret way, into the wilderness; and thus when Helaman sent forth to take them they could nowhere be found.

And more of this Gadianton shall be spoken hereafter. And thus ended the forty and second year of the reign of the judges over the people of Nephi.

And behold, in the end of this book ye shall see that this Gadianton did prove the overthrow, yea, almost the entire destruction of the people of Nephi.

Behold I do not mean the end of the book of Helaman, but I mean the end of the book of Nephi, from which I have taken all the account which I have written.

### Хиламан 3

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор дөчин гуравдугаар оны төгсгөлд хэргүүд нь шийдэгдсэн, зарим жижиг тэрслэлүүдийг хүмүүсийн дунд бий болгосон, бага зэрэг бардамнал сүмийн дотор байснаас бусдаар бол Нифайн хүмүүсийн дунд шүүгчдийн засаглалын дөчин гуравдугаар онд ямар ч зөрчилдөөн байсангүй.
- 2 Мөн дөчин дөрөвдүгээр онд хүмүүсийн дунд ямар ч зөрчилдөөн байсангүй; бас дөчин тавдугаар онд их зөрчилдөөн байсангүй.
- 3 Мөнхүү улиран тохиох дор дөчин зургадугаар онд, тийм ээ, их зөрчилдөөн мөн олон тэрслэл байв; үүний дүнд Зарахемла нутгаас гарч одоод, мөн умард нутаг тийш уг нутгийг өвлөхөөр явсан нь үлэмж олон байв.
- 4 Мөн тэд үлэмж агуу хол зайг аялан туулж, үүний хэрээр тэд томхон нуурууд мөн олон голуудад тулж ирэв.
- 5 Тийм ээ, мөн уг нутгийн бүх хэсэгт, урьд нь уг нутгийг өвлөсөн олон оршин суугчдын учир модгүй мөн үржил шимгүй болгоогүй хэсгүүдэд тархан суурьшив.
- 6 Мөн эдүгээ ургаа модгүй л болохоос биш, уг нутгийн аль ч хэсэг нь үржил шимгүй байсангүй; гэвч урьд нь өвлөж байсан хүмүүсийн устгалын агуу ихийн учир уг нутаг үржил шимгүй хэмээгдэж байв.
- 7 Мөн уг нутгийн гадаргуу дээр зөвхөн багахан хэмжээний л ургаа мод үлдсэн учир, тиймийн тул нүүж ирсэн хүмүүс зуурмагаар ажиллахдаа үлэмж мэргэшив; тиймийн тул тэд дотор нь оршин суух зуурмаган байшингууд барив.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд өнөржиж мөн тархаж, мөн өмнөд нутгаас умард нутагт одож, мөн тархаж үүнийхээ хэрээр тэд бүхэл дэлхийн гадаргууг, өмнөд тэнгисээс умард тэнгисийг хүртэл, өрнөд тэнгисээс дорнод тэнгисийг хүртэл бүрхэж эхлэв.
- 9 Мөн умард нутагт байсан хүмүүс майхнууд, мөн зуурмаган байшингуудад оршин суудаг байв, мөн тэд хойшид байшингуудаа, тийм ээ, хотуудаа, мөн ариун сүмүүдээ, мөн синагогуудаа, мөн дугануудаа, мөн төрөл бүрийн барилгуудаа барих ургаа модтой байж болохын тулд тэд уг нутгийн гадаргуу дээр нахиалах мод бүрийг ургуулахаар болов.

### Helaman 3

And now it came to pass in the forty and third year of the reign of the judges, there was no contention among the people of Nephi save it were a little pride which was in the church, which did cause some little dissensions among the people, which affairs were settled in the ending of the forty and third year.

And there was no contention among the people in the forty and fourth year; neither was there much contention in the forty and fifth year.

And it came to pass in the forty and sixth, yea, there was much contention and many dissensions; in the which there were an exceedingly great many who departed out of the land of Zarahemla, and went forth unto the land northward to inherit the land.

And they did travel to an exceedingly great distance, insomuch that they came to large bodies of water and many rivers.

Yea, and even they did spread forth into all parts of the land, into whatever parts it had not been rendered desolate and without timber, because of the many inhabitants who had before inherited the land.

And now no part of the land was desolate, save it were for timber; but because of the greatness of the destruction of the people who had before inhabited the land it was called desolate.

And there being but little timber upon the face of the land, nevertheless the people who went forth became exceedingly expert in the working of cement; therefore they did build houses of cement, in the which they did dwell.

And it came to pass that they did multiply and spread, and did go forth from the land southward to the land northward, and did spread insomuch that they began to cover the face of the whole earth, from the sea south to the sea north, from the sea west to the sea east.

And the people who were in the land northward did dwell in tents, and in houses of cement, and they did suffer whatsoever tree should spring up upon the face of the land that it should grow up, that in time they might have timber to build their houses, yea, their cities, and their temples, and their synagogues, and their sanctuaries, and all manner of their buildings.

10 Мөнхүү улиран тохиох дор умард нутагт ургаа мод үлэмж ховор байсны учир, тэд усан онгоцоор ихийг илгээж байв.

11 Мөн тэд тийн тэднийг модоор бас зуурмагаар аль алинаар нь, олон хот барьж болохыг умард нутгийн хүмүүст боломжтой болгодог байв.

12 Мөнхүү улиран тохиох дор уг гарал нь лемен үндэстэн болох Аммоны хүмүүсээс олон нь түүнчлэн тэр нутаг тийш оджээ.

13 Мөн энэ хүмүүсийн олноор нь, энэ хүмүүсийн хэрэг явдлын тухай, тэдний талаарх тодорхой мөн маш том олон цэдэг хөтлөгдөв.

14 Гэвч болгоогтун, леменчүүдийн мөн нифайчуудын, мөн тэдний дайнуудын, мөн зөрчилдөөнүүд, мөн тэрслэлүүд, мөн тэдний номлолууд, мөн тэдний бошиглолууд, мөн тэдний усан онгоцоор илгээдэг байсны нь, мөн тэдний усан онгоц барьдаг байсны нь, мөн тэдний ариун сүмүүд мөн синагогууд мөн дугануудыг барьдаг байсны нь, мөн тэдний зөв шударга байдал, мөн тэдний ёс бус байдал, мөн тэдний аллагууд, мөн тэдний дээрмүүд, мөн тэдний тонуулууд, мөн бүх төрлийн жигшүүрт хэргүүд мөн садар самуун явдлын талаарх шастир, тийм ээ, энэ хүмүүсийн хэрэг явдлуудын зууны нэг хэсэг нь ч үүнд агуулагдаж чадахгүй юм.

15 Гэвч болгоогтун, олон ном мөн төрөл бүрийн олон цэдэг буй, мөн тэдгээр нь ихэвчлэн нифайчуудаар хөтлөгдөж байв.

16 Мөн бүр тэд зөрчилд унасан мөн алагдан, дээрэмдүүлж, мөн мөрдөгдөн, мөн туугдаж, мөн хядагдан, мөн газрын гадаргуу дээр тараагдах хүртэл, мөн ёс бус, мөн зэрлэг, мөн хэрцгий болсон учир, тийм ээ, бүр леменчүүд болсон учир, хойшид нифайчууд хэмээн нэрлэгдэхгүй болтлоо леменчүүдтэй хутгалдах хүртэл тэдгээр нь нэг үеэс нөгөөд нифайчуудаар гардуулагдсаар ирсэн бөлгөө.

17 Мөн эдүгээ би дахин өөрийн шастирт эргэн оръё; тиймийн тул, миний ярьсан нь Нифайн хүмүүсийн дундах агуу зөрчилдөөн, мөн саад бэрхшээлүүд, мөн дайнууд, мөн тэрслэлүүдийн дараа тохиосон байв.

18 Шүүгчдийн засаглалын дөчин зургадугаар он төгсөв;

And it came to pass as timber was exceedingly scarce in the land northward, they did send forth much by the way of shipping.

And thus they did enable the people in the land northward that they might build many cities, both of wood and of cement.

And it came to pass that there were many of the people of Ammon, who were Lamanites by birth, did also go forth into this land.

And now there are many records kept of the proceedings of this people, by many of this people, which are particular and very large, concerning them.

But behold, a hundredth part of the proceedings of this people, yea, the account of the Lamanites and of the Nephites, and their wars, and contentions, and dissensions, and their preaching, and their prophecies, and their shipping and their building of ships, and their building of temples, and of synagogues and their sanctuaries, and their righteousness, and their wickedness, and their murders, and their robbings, and their plundering, and all manner of abominations and whoredoms, cannot be contained in this work.

But behold, there are many books and many records of every kind, and they have been kept chiefly by the Nephites.

And they have been handed down from one generation to another by the Nephites, even until they have fallen into transgression and have been murdered, plundered, and hunted, and driven forth, and slain, and scattered upon the face of the earth, and mixed with the Lamanites until they are no more called the Nephites, becoming wicked, and wild, and ferocious, yea, even becoming Lamanites.

And now I return again to mine account; therefore, what I have spoken had passed after there had been great contentions, and disturbances, and wars, and dissensions, among the people of Nephi.

The forty and sixth year of the reign of the judges ended;

- 19 Мөнхүү улиран тохиох дор уг нутагт, тийм ээ, бүр дөчин долдугаар онд, мөн түүнчлэн дөчин наймдугаар онд агуу зөрчилдөөн байсаар байв.
- 20 Гэсэн хэдий ч Хиламан шударга ёс мөн тэгш эрхийг хүндэтгэн үзэж шүүлтийн суудлыг эзлэв; тийм ээ, тэрээр Бурханы тогтоолууд, мөн шүүлтүүд, мөн зарлигуудыг дагахыг хичээв; мөн тэрбээр Бурханы мэлмийд үргэлж зөвийг үйлдэж байв; мөн тэрбээр эцгийнхээ замуудаар алхсан юм, үүнийхээ хэрээр тэрээр уг нутагт дэгжив.
- 21 Мөнхүү улиран тохиох дор түүнд хоёр хөвгүүн төрсөн аж. Тэрбээр ахмадад нь Нифайн нэрийг, мөн багад нь Лихайн нэрийг өгчээ. Мөн тэд Их Эзэний төлөө өсөж эхлэв.
- 22 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын дөчин наймдугаар оны төгсгөлд, нифайчуудын ардын дунд, дайнууд мөн зөрчилдөөнүүд бага зэргээр намдаж эхлэв.
- 23 Мөнхүү улиран тохиох дор уг нутгийн илүү хүн суурьшсан хэсгүүдэд дээрэмчин Гадантоны байгуулсан, нууц хуйвалдаанууд байснаас бусдаар бол шүүгчдийн засаглалын дөчин ес дэх онд уг нутагт үргэлжийн амар амгалан тогтоогдов, тэдгээр хуйвалдаанууд тэр үедээ засгийн газрын тэргүүнд байсан тэдэнд мэдэгдсэнгүй; тиймийн тул тэд уг нутагт устгагдсангүй.
- 24 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд сүмд үлэмж агуу дэгжилт гарав, үүний хэрээр өөрсдөө сүмд нэгдэн мөн наманчлалд хүргэгдэн баптисм хүртсэн нь мянга мянгаараа байв.
- 25 Мөн бүр дээд санваартнууд мөн багш нар өөрсдөө хэмжээлшгүй ихээр гайхан бахадсан сүмийн дэгжилт тийм агуу байж, мөн хүмүүсийн дээр юүлэгдсэн адислалууд тийм олон байв.
- 26 Мөнхүү улиран тохиох дор олон бодгаль, тийм ээ, бүр хэдэн арван мянга нь Бурханы сүмд баптисм хүртэж мөн нэгдсэнээр Их Эзэний ажил дэгжив.
- 27 Зүрх сэтгэлийнхээ гүнээс, түүний ариун нэрийг дуудах бүгдэд Их Эзэн нигүүлсэнгүй байдгийг бид ийн үзэж болох ажгуу.
- 28 Тийм ээ, бүгдэд, бүр Бурханы Хүү болох Есүс Христийн нэрэнд итгэдэг тэдэнд, тэнгэрийн хаалга нээлтгэйг бид тийн харлаа.

And it came to pass that there was still great contention in the land, yea, even in the forty and seventh year, and also in the forty and eighth year.

Nevertheless Helaman did fill the judgment-seat with justice and equity; yea, he did observe to keep the statutes, and the judgments, and the commandments of God; and he did do that which was right in the sight of God continually; and he did walk after the ways of his father, insomuch that he did prosper in the land.

And it came to pass that he had two sons. He gave unto the eldest the name of Nephi, and unto the youngest, the name of Lehi. And they began to grow up unto the Lord.

And it came to pass that the wars and contentions began to cease, in a small degree, among the people of the Nephites, in the latter end of the forty and eighth year of the reign of the judges over the people of Nephi.

And it came to pass in the forty and ninth year of the reign of the judges, there was continual peace established in the land, all save it were the secret combinations which Gadianton the robber had established in the more settled parts of the land, which at that time were not known unto those who were at the head of government; therefore they were not destroyed out of the land.

And it came to pass that in this same year there was exceedingly great prosperity in the church, insomuch that there were thousands who did join themselves unto the church and were baptized unto repentance.

And so great was the prosperity of the church, and so many the blessings which were poured out upon the people, that even the high priests and the teachers were themselves astonished beyond measure.

And it came to pass that the work of the Lord did prosper unto the baptizing and uniting to the church of God, many souls, yea, even tens of thousands.

Thus we may see that the Lord is merciful unto all who will, in the sincerity of their hearts, call upon his holy name.

Yea, thus we see that the gate of heaven is open unto all, even to those who will believe on the name of Jesus Christ, who is the Son of God.

- 29 Тийм ээ, чөтгөрийн бүх башир аргыг мөн урхи мөн арга залиг нь тасчин хуваах, амьд хүчирхэг, мөн ёс бусыг үйлдэгчдийг залгихаар бэлтгэгдсэн зовлонгийн үүрдийн ангал дээгүүр гарах давчуу бөгөөд нарийн замаар Христийн хүмүүнийг удирдах, Бурханы үгэн дээр тулгуурлахыг хүсэх хэн боловч тулгуурлаж—
- 30 Мөн тэнгэрийн хаант улсад, Бурханы баруун мутар талд, Абрахамтай, мөн Исаактай, мөн Иаковтай хамт, мөн бидний бүх ариун эцэг өвгөдийн хамт, цаашид гарахгүйгээр суухаар өөрсдийн бодгалиудыг, тийм ээ, үхэшгүй бодгалиудаа байрлуулж болохыг бид харж болно.
- 31 Мөн тэрхүү онд Зарахемла нутагт, мөн эргэн тойрны бүх бүс нутгуудад, бүр нифайчуудаар эзэмшигдсэн бүх нутагт үргэлжийн баясал байв.
- 32 Мөнхүү улиран тохиох дор дөчин есдүгээр оны үлдсэн хугацаанд амар амгалан мөн үлэмж агуу баяр хөөр байв; тийм ээ, мөн шүүгчдийн засаглалын тавьдугаар онд түүнчлэн үргэлжийн амар амгалан мөн агуу баяр хөөр байв.
- 33 Мөн шүүгчдийн засаглалын тавин нэгдүгээр онд, сүмд нэвтэрч эхэлсэн—Бурханы сүмд бус, харин Бурханы сүмд харьяалагддаг хэмээх хүмүүсийн зүрх сэтгэлд орж эхэлсэн—бардамналаас бусдаар бол түүнчлэн амар амгалан байв.
- 34 Мөн тэд, бүр ах дүүсийнхээ олныг нь хавчин гадуурхах хүртлээ бардамналдаа хөөрч байв. Эдүгээ энэ нь хүмүүсийн илүү даруухан хэсгийг их хавчлагыг тэсвэрлэхэд, мөн их зовлонгийн дундуур туулахад хүргэсэн тэрхүү агуу хилэнц байв.
- 35 Гэсэн хэдий ч сэтгэл оюун нь баясал хийгээд тайтгарлаар дүүрэх хүртлээ, тийм ээ, зүрх сэтгэлээ Бурханд зориулсны учир ирэх ариушлаар зүрх сэтгэл нь бүр ариусаж мөн цэвэрших хүртлээ, тэд ойр ойрхон мацаг барьж мөн залбирч, мөн даруу байдалдаа улам улам хүчирхэг мөн Христийн бишрэлд улам улам гуйвшгүй бат болж байв.

Yea, we see that whosoever will may lay hold upon the word of God, which is quick and powerful, which shall divide asunder all the cunning and the snares and the wiles of the devil, and lead the man of Christ in a strait and narrow course across that everlasting gulf of misery which is prepared to engulf the wicked—

And land their souls, yea, their immortal souls, at the right hand of God in the kingdom of heaven, to sit down with Abraham, and Isaac, and with Jacob, and with all our holy fathers, to go no more out.

And in this year there was continual rejoicing in the land of Zarahemla, and in all the regions round about, even in all the land which was possessed by the Nephites.

And it came to pass that there was peace and exceedingly great joy in the remainder of the forty and ninth year; yea, and also there was continual peace and great joy in the fiftieth year of the reign of the judges.

And in the fifty and first year of the reign of the judges there was peace also, save it were the pride which began to enter into the church—not into the church of God, but into the hearts of the people who professed to belong to the church of God—

And they were lifted up in pride, even to the persecution of many of their brethren. Now this was a great evil, which did cause the more humble part of the people to suffer great persecutions, and to wade through much affliction.

Nevertheless they did fast and pray oft, and did wax stronger and stronger in their humility, and firmer and firmer in the faith of Christ, unto the filling their souls with joy and consolation, yea, even to the purifying and the sanctification of their hearts, which sanctification cometh because of their yielding their hearts unto God.

36 Мөнхүү улиран тохиох дор тавин хоёр дахь он, мөн тэдний үлэмж их баялаг мөн уг нутаг дахь хөгжил дэгжлийн улмаас хүмүүсийн зүрх сэтгэлд нэвтэрсэн үлэмж агуу бардамналаас бусдаар бол түүнчлэн амар амгаланд төгсөв; мөн энэхүү бардамнал өдрөөс өдөрт тэдний дээр өсөн нэмэгдэж байв.

37 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын тавин гуравдугаар онд, Хиламан нас нөгчиж, мөн түүний ахмад хүү Нифай түүний оронд засаглаж эхлэв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр шударга ёс хийгээд тэгш эрхийг хүндэтгэж үзэн шүүлтийн суудлыг эзэлжээ; тийм ээ, тэрээр Бурханы зарлигуудыг дагаж, мөн эцгийнхээ замуудаар алхалсан болой.

And it came to pass that the fifty and second year ended in peace also, save it were the exceedingly great pride which had gotten into the hearts of the people; and it was because of their exceedingly great riches and their prosperity in the land; and it did grow upon them from day to day.

And it came to pass in the fifty and third year of the reign of the judges, Helaman died, and his eldest son Nephi began to reign in his stead. And it came to pass that he did fill the judgment-seat with justice and equity; yea, he did keep the commandments of God, and did walk in the ways of his father.

## Хиламан 4

- 1 Мөнхүү улиран тохиох дор тавин дөрөвдүгээр онд сүмд олон тэрслэл байж, мөн түүнчлэн хүмүүсийн дунд зөрчилдөөн байж, үүний хэрээр ихээхэн цус урсгалт байв.
- 2 Мөн эсэргүүцсэн хэсэг нь алагдаж мөн уг нутгаас туугдаж, мөн тэд леменчүүдийн хаанд очив.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчуудын эсрэг дайнд леменчүүдийг өдөөн хатгахаар чармайн оролдсон аж; гэвч болгоогтун, леменчүүд үлэмж айж, үүний хэрээр тэд тэрслэгчдийн үгсийг анхааран сонсохгүй байв.
- 4 Гэвч улиран тохиох дор шүүгчдийн засаглалын тавин зургадугаар онд, нифайчуудаас леменчүүдэд одсон тэрслэгчид байв; мөн тэд бусадтайгаа тэднийг нифайчуудын эсрэг ууранд өдөөн хатгахад амжилт олов; мөн тэд тэрхүү оны турш дайнд бэлтгэжээ.
- 5 Мөн тавин долдугаар онд тэд нифайчуудын эсрэг тулалдахаар ирж, мөн тэд үхлийн ажлыг эхэлсэн болой; тийм ээ, үүний хэрээр шүүгчдийн засаглалын тавин наймдугаар онд тэд Зарахемла нутгийг; тийм ээ, мөн түүнчлэн, бүр Өгөөмөр нутгийн дэргэд байсан нутгийг хүртэлх бүх нутгийг эзэмшилдээ авахад амжилт олов.
- 6 Мөн нифайчууд мөн Моронайхагийн их цэрэг бүр Өгөөмөр нутаг хүртэл туугдав;
- 7 Мөн леменчүүдийн эсрэг тэнд, өрнөд тэнгисээс, бүр дорнодыг хүртэл тэд бэхлэн суув; тэдний бэхлсэн мөн умард нутгаа батлан хамгаалуулахаар их цэргээ байрлуулсан тэр хилийг дагах нь нифай үндэстэн хүний хувьд нэг өдрийн аян байв.
- 8 Мөн тийн нифайчуудын тэдгээр тэрслэгчид леменчүүдийн олон тоотой их цэргийн тусламжтайгаар өмнөд нутагт байсан нифайчуудын бүх эзэмшлийг олж авсан байв. Мөн энэ бүгд нь шүүгчдийн засаглалын тавин найм мөн тавин есдүгээр онуудад хийгдэв.

## Helaman 4

And it came to pass in the fifty and fourth year there were many dissensions in the church, and there was also a contention among the people, insomuch that there was much bloodshed.

And the rebellious part were slain and driven out of the land, and they did go unto the king of the Lamanites.

And it came to pass that they did endeavor to stir up the Lamanites to war against the Nephites; but behold, the Lamanites were exceedingly afraid, insomuch that they would not hearken to the words of those dissenters.

But it came to pass in the fifty and sixth year of the reign of the judges, there were dissenters who went up from the Nephites unto the Lamanites; and they succeeded with those others in stirring them up to anger against the Nephites; and they were all that year preparing for war.

And in the fifty and seventh year they did come down against the Nephites to battle, and they did commence the work of death; yea, insomuch that in the fifty and eighth year of the reign of the judges they succeeded in obtaining possession of the land of Zarahemla; yea, and also all the lands, even unto the land which was near the land Bountiful.

And the Nephites and the armies of Moronihah were driven even into the land of Bountiful;

And there they did fortify against the Lamanites, from the west sea, even unto the east; it being a day's journey for a Nephite, on the line which they had fortified and stationed their armies to defend their north country.

And thus those dissenters of the Nephites, with the help of a numerous army of the Lamanites, had obtained all the possession of the Nephites which was in the land southward. And all this was done in the fifty and eighth and ninth years of the reign of the judges.

- 9 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жардугаар онд, Моронайха их цэргийнхээ хамт уг нутгийн олон хэсгийг авахад амжилт олов; тийм ээ, тэд леменчүүдийн гарт орсон олон хотыг буцаан авсан ажгуу.
- 10 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаран нэгдүгээр онд тэд бүх эзэмшлийнхээ бүр хагасыг нь буцаан авахад амжилт олов.
- 11 Эдүгээ тэдний дунд байсан, тийм ээ, мөн Бурханы сүмд харьяалагдах хэмээсэн тэдний дунд түүнчлэн байсан өөрсдийнх нь ёс бус, мөн жигшүүрт хэргүүд байгаагүй бол нифайчуудын энэ агуу алдагдал, мөн тэдний дунд байсан агуу аллага тохиохгүй байсан биз ээ.
- 12 Мөн тэдний зүрх сэтгэлийн бардамналын учир, тэдний үлэмж баялгийн нь учир, тийм ээ, тэд ядууг дарамталж, өлссөнөөс хоолоо харамласан учир, нүцгэнээс хувцсаа харамласан учир, даруухан ах дүүсээ хацар дээр нь алгасан учир, ариун нандиныг элэг доог болгосон учир, бошиглолын болон илчлэлтийн суу билгийг үгүйсгэсэн учир, тэд аллага дээрэм, худал хуурмаг, хулгай, садар самууныг үйлдсэн учир, тэд агуу их зөрчилдөөнийг үүсгэсэн учир, мөн тэд зайлан одож, леменчүүдийн дунд Нифайн нутагт орсон учир—
- 13 Мөн тэдний энэ агуу ёс бусын учир, мөн тэд эрдэн хүчиндээ барддагийн учир, тэд өөрсдийнхөө хүчинд орхигдов; тиймийн тул тэд дэгжсэнгүй, харин тэд нутгийнхаа бараг бүх эзэмшлийг алдах хүртлээ зовоогдож мөн цохигдож мөн леменчүүдийн өмнө туугдав.
- 14 Гэвч болгоогтун, тэдний алдсуудын учир Моронайха олон зүйлийг хүмүүст номлов, мөн түүнчлэн Хиламаны хөвгүүд, Нифай, Лихай нар, хүмүүст олон зүйлийг номлож, тийм ээ, тэдний алдсуудын талаар мөн хэрэв тэд нүглүүдээ наманчлаггүй аваас тэдний дээр юу ирэх ёстой талаар олон зүйлийг бошиглосон болой.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэд наманчилж, мөн тэд наманчилсныхаа хэрээр тэд дэгжиж эхлэв.

And it came to pass in the sixtieth year of the reign of the judges, Moronihah did succeed with his armies in obtaining many parts of the land; yea, they regained many cities which had fallen into the hands of the Lamanites.

And it came to pass in the sixty and first year of the reign of the judges they succeeded in regaining even the half of all their possessions.

Now this great loss of the Nephites, and the great slaughter which was among them, would not have happened had it not been for their wickedness and their abomination which was among them; yea, and it was among those also who professed to belong to the church of God.

And it was because of the pride of their hearts, because of their exceeding riches, yea, it was because of their oppression to the poor, withholding their food from the hungry, withholding their clothing from the naked, and smiting their humble brethren upon the cheek, making a mock of that which was sacred, denying the spirit of prophecy and of revelation, murdering, plundering, lying, stealing, committing adultery, rising up in great contentions, and deserting away into the land of Nephí, among the Lamanites—

And because of this their great wickedness, and their boastings in their own strength, they were left in their own strength; therefore they did not prosper, but were afflicted and smitten, and driven before the Lamanites, until they had lost possession of almost all their lands.

But behold, Moronihah did preach many things unto the people because of their iniquity, and also Nephi and Lehi, who were the sons of Helaman, did preach many things unto the people, yea, and did prophesy many things unto them concerning their iniquities, and what should come unto them if they did not repent of their sins.

And it came to pass that they did repent, and inasmuch as they did repent they did begin to prosper.



16 Өөрөөр хэлбэл Моронайха тэдний наманчилсныг хараад, тэрээр тэднийг нэг газраас нөгөө газарт, мөн хотоос хотод, бүр тэд хөрөнгийнхөө хагасыг мөн бүх нутгийнхаа хагасыг буцаан авах хүртэл удирдахаар зориглосон ажээ.

17 Мөн шүүгчдийн засаглалын жаран нэгдүгээр он тийн төгсөв.

18 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаран хоёрдугаар онд, Моронайха цаашид леменчүүдийг даван эзэмшлийг олж авч чадсангүй.

19 Тиймийн тул тэд нутгийнхаа үлдсэнийг нь олж авах гэсэн төлөвлөгөөгөө орхив, учир нь леменчүүд тийм олон тоотой байснаас, тэднийг давамгайлах илүү хүчийг олох нь нифайчуудын хувьд боломжгүй болов; тиймийн тул Моронайха өөрийн авсан хэсгүүдээ хадгалан хамгаалахад бүх их цэргээ дайчлав.

20 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн тооных нь агуу ихийн учир дийлэгдэж, мөн дэвслэгдэн, мөн алагдан, мөн устгагдах болуузай хэмээн ихэд айсан байдалд нифайчууд байв.

21 Тийм ээ, тэд Алмагийн бошиглолууд, мөн түүнчлэн Мозаягийн үгсийг санаж эхлэв; мөн тэд зөрүүд хүмүүс байснаа, мөн тэд Бурханы зарлигуудыг үл ойшоосноо ухаарав;

22 Мөн тэд Мозаягийн хуулиудыг өөрөөр хэлбэл хүмүүст өгөхийг Их Эзэн түүнд зарлигласан тэдгээрийг хөл доороо гишгэлснээ мөн өөрчилснөө; мөн тэд хуулиуд нь завхруулагдаж, мөн тэд ёс бус хүмүүс болж, үүний хэрээр тэд ёс бус, бүр леменчүүдийн адил байснаа тэд ухаарав.

23 Мөн тэдний алдсын учир сүм бууран доройтож эхэлсэн байв; мөн тэд бошиглолын суу билэг, илчлэлтийн суу билэгт итгэхгүй болж эхлэв; мөн Бурханы шүүлтүүд нүүрэн дээр нь тулж иржээ.

24 Мөн тэд ах дүүсийнхээ, леменчүүдийн адил сул дорой болсноо, мөн Их Эзэний Сүнс тэднийг цаашид хамгаалахаа больсныг ухаарав; тийм ээ, Их Эзэний Сүнс ариун бус дугануудад үл оршихын учир энэ нь тэднийг орхисон байв—

For when Moronihah saw that they did repent he did venture to lead them forth from place to place, and from city to city, even until they had regained the one-half of their property and the one-half of all their lands.

And thus ended the sixty and first year of the reign of the judges.

And it came to pass in the sixty and second year of the reign of the judges, that Moronihah could obtain no more possessions over the Lamanites.

Therefore they did abandon their design to obtain the remainder of their lands, for so numerous were the Lamanites that it became impossible for the Nephites to obtain more power over them; therefore Moronihah did employ all his armies in maintaining those parts which he had taken.

And it came to pass, because of the greatness of the number of the Lamanites the Nephites were in great fear, lest they should be overpowered, and trodden down, and slain, and destroyed.

Yea, they began to remember the prophecies of Alma, and also the words of Mosiah; and they saw that they had been a stiffnecked people, and that they had set at naught the commandments of God;

And that they had altered and trampled under their feet the laws of Mosiah, or that which the Lord commanded him to give unto the people; and they saw that their laws had become corrupted, and that they had become a wicked people, insomuch that they were wicked even like unto the Lamanites.

And because of their iniquity the church had begun to dwindle; and they began to disbelieve in the spirit of prophecy and in the spirit of revelation; and the judgments of God did stare them in the face.

And they saw that they had become weak, like unto their brethren, the Lamanites, and that the Spirit of the Lord did no more preserve them; yea, it had withdrawn from them because the Spirit of the Lord doth not dwell in unholy temples—

25 Тиймийн тул Их Эзэн тэднийг өөрийн гайхамшигт мөн зүйрлэшгүй хүчээр хамгаалахаа больж, учир нь тэд итгэлгүй мөн аймшигт ёс бусын байдалд унасан байв; мөн тэднээс леменчүүд үлэмж илүү олон тоотой, мөн тэд Их Эзэн Бурхандаа үнэнч байхгүй аваас тэд гарцаагүй мөхөх ёстойг тэд ойлгов.

26 Учир нь болгоогтун, леменчүүдийн хүч чадал тэдний хүч чадлын адил агуу, бүр нэг хүн нэгтэйгээ тэнцэхүйц байсныг тэд ойлгов. Мөн тэд энэ агуу зөрчилд тийн унасан байв; тийм ээ, тэд тийн зөрчлийнхөө учир олон бус жилийн хугацаанд сул дорой болсон байв.

Therefore the Lord did cease to preserve them by his miraculous and matchless power, for they had fallen into a state of unbelief and awful wickedness; and they saw that the Lamanites were exceedingly more numerous than they, and except they should cleave unto the Lord their God they must unavoidably perish.

For behold, they saw that the strength of the Lamanites was as great as their strength, even man for man. And thus had they fallen into this great transgression; yea, thus had they become weak, because of their transgression, in the space of not many years.

## Хиламан 5

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд, болгоогтун, Нифай шүүлтийн суудлыг нэр нь Сизром гэдэг асан хүнд шилжүүлэв.
- 2 Учир нь тэдний хуулиуд хийгээд засгийн газар нь хүмүүсийн саналаар тогтоогддог байв, мөн хилэнцтийг сонгосон тэд сайныг сонгосон тэднээс илүү олон тоотой байсан учир, тиймийн тул тэд устгалдаа боловсорч гүйцээд байв, учир нь хуулиуд нь завхруулагдсан байжээ.
- 3 Тийм ээ, мөн энэ нь бүгд бус; тэд зөрүүд хүмүүс байв, үүний хэрээр устгал уруугаа бус аваас тэд хуулиар бас шударга ёсоор захирагдаж чадсангүй бөлгөө.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэдний алдсын учир Нифай туйлдсан байв; мөн тэрбээр шүүлтийн суудлыг өгч, мөн үлдсэн бүх өдрүүддээ мөн дүү Лихай нь ч түүнчлэн, өөрийн үлдсэн бүх өдрүүдэд Бурханы үгийг номлох үүргийг өөртөө хүлээн авав;
- 5 Учир нь тэд эцэг Хиламаныхаа тэдэнд ярьсан үгсийг санасан ажээ. Мөн түүний ярьсан үгс нь эдгээр болой:
- 6 Болгоогтун, хөвгүүд минь, та нар Бурханы зарлигуудыг дагахыг санаасай хэмээн хүснэ би; мөн та нар хүмүүст эдгээр үгсийг тунхаглаасай хэмээнэ би. Болгоогтун, Иерусалимын нутгаас гарч ирсэн анхны эцэг өвгөдийнхөө нэрсийг би та нарт өгсөн билээ; мөн та нар өөрсдийн нэрсийг санахдаа тэднийг санаж болно хэмээн би үүнийг хийсэн; мөн та нар тэднийг санахдаа та нар тэдний үйлүүдийг санаж болно; мөн та нар тэдний үйлүүдийг санахдаа тэдгээр нь сайн байсан гэдэг нь хэлэгдэж, мөн түүнчлэн бичиглэгдсэнийг мэдэж болно.
- 7 Тиймийн тул, хөвгүүд минь, бүр тэдний тухай хэлэгдэж мөн бичигдсэн шиг, та нарын тухай хэлэгдэж, мөн түүнчлэн бичиглэгдэж болохын тулд, сайн болох түүнийг та нар үйлдээсэй хэмээнэ би.

## Helaman 5

And it came to pass that in this same year, behold, Nephi delivered up the judgment-seat to a man whose name was Cezoram.

For as their laws and their governments were established by the voice of the people, and they who chose evil were more numerous than they who chose good, therefore they were ripening for destruction, for the laws had become corrupted.

Yea, and this was not all; they were a stiffnecked people, insomuch that they could not be governed by the law nor justice, save it were to their destruction.

And it came to pass that Nephi had become weary because of their iniquity; and he yielded up the judgment-seat, and took it upon him to preach the word of God all the remainder of his days, and his brother Lehi also, all the remainder of his days;

For they remembered the words which their father Helaman spake unto them. And these are the words which he spake:

Behold, my sons, I desire that ye should remember to keep the commandments of God; and I would that ye should declare unto the people these words. Behold, I have given unto you the names of our first parents who came out of the land of Jerusalem; and this I have done that when you remember your names ye may remember them; and when ye remember them ye may remember their works; and when ye remember their works ye may know how that it is said, and also written, that they were good.

Therefore, my sons, I would that ye should do that which is good, that it may be said of you, and also written, even as it has been said and written of them.

- 8 Мөн эдүгээ хөвгүүд минь, болгоогтун би өөр заримыг та нараас хүсэх нь, та нар бардамнаж болохын тул эдгээр зүйлийг хийж болох бус, харин тийм ээ, та нар өөрсдөдөө мөнхийн болох тэрхүү, мөн онгож гандаад алга болох нь үгүй, тэрхүү эрдэнэсийг тэнгэрт хураахаар эдгээр зүйлийг хийж болно; тийм ээ, бидний эцэг өвгөдөд өгөгдсөн хэмээн бодох шалтгаан бидэнд буй, мөнх амьдралын эрхэм үнэт бэлэг та нарт байж болохыг эгээрэх тэрхүү хүсэл юм.
- 9 Ай санагтун, санагтун, хөвгүүд минь, хаан Бенжамин өөрийн хүмүүст ярьсан үгсийг; тийм ээ, хүмүүн аврагдаж чадах өөр бусад зам ч, бас арга ч үгүй, зөвхөн ирэх, Есүс Христийн цагаатгагч цусаар дамжин гэдгийг санагтун; тийм ээ, тэрээр энэ дэлхийг гэтэлгэхээр ирэхийг санагтун.
- 10 Мөн Аммонайха хотод, Зиезромд ярьсан Амюлекийн үгсийг ч түүнчлэн санагтун; тодруулбал тэрбээр Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр гарцаагүй ирэх болно, гэвч тэрээр тэднийг нүгэлд нь гэтэлгэхээр ирэх бус, харин тэднийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирнэ хэмээн түүнд хэлсэн билээ.
- 11 Мөн наманчлалын учир нүглүүдээс нь тэднийг гэтэлгэхээр Эцэгээс түүнд хүч өгөгдсөн буй; тиймийн тул Гэтэлгэгчийн хүчинд, бодгалиудынх нь авралд хүргэх, наманчлалын нөхцөлүүдийн мэдээг тунхаглуулахаар тэрээр тэнгэр элчүүдээ илгээсэн билээ.
- 12 Мөн эдүгээ, хөвгүүд минь, санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дахь дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой.
- 13 Мөнхүү улиран тохиох дор хөвгүүддээ Хиламаны заасан үгс нь эдгээр байсан болой; тийм ээ, тэрээр бичигдээгүй олон зүйлийг, мөн түүнчлэн бичигдсэн олон зүйлийг тэдэнд заажээ.

And now my sons, behold I have somewhat more to desire of you, which desire is, that ye may not do these things that ye may boast, but that ye may do these things to lay up for yourselves a treasure in heaven, yea, which is eternal, and which fadeth not away; yea, that ye may have that precious gift of eternal life, which we have reason to suppose hath been given to our fathers.

O remember, remember, my sons, the words which king Benjamin spake unto his people; yea, remember that there is no other way nor means whereby man can be saved, only through the atoning blood of Jesus Christ, who shall come; yea, remember that he cometh to redeem the world.

And remember also the words which Amulek spake unto Zeezrom, in the city of Ammonihah; for he said unto him that the Lord surely should come to redeem his people, but that he should not come to redeem them in their sins, but to redeem them from their sins.

And he hath power given unto him from the Father to redeem them from their sins because of repentance; therefore he hath sent his angels to declare the tidings of the conditions of repentance, which bringeth unto the power of the Redeemer, unto the salvation of their souls.

And now, my sons, remember, remember that it is upon the rock of our Redeemer, who is Christ, the Son of God, that ye must build your foundation; that when the devil shall send forth his mighty winds, yea, his shafts in the whirlwind, yea, when all his hail and his mighty storm shall beat upon you, it shall have no power over you to drag you down to the gulf of misery and endless wo, because of the rock upon which ye are built, which is a sure foundation, a foundation whereon if men build they cannot fall.

And it came to pass that these were the words which Helaman taught to his sons; yea, he did teach them many things which are not written, and also many things which are written.

14 Мөн тэд түүний үгсийг санасан аж; мөн тиймийн тул тэд Бурханы зарлигуудыг даган, Бурханы үгийг Нифайн бүх хүмүүсийн дунд заахаар одож, Өгөөмөр хотоос эхлэв;

15 Мөн тэндээс цаашлан Гид хотод; мөн Гид хотоос Мюлек хотод;

16 Мөн бүр нэг хотоос нөгөөд, тэд өмнөд нутагт байсан Нифайн бүх хүмүүсийн дунд очих хүртлээ явж; мөн тэндээс Зарахемла нутагт, леменчүүдийн дунд очив.

17 Мөнхүү улиран тохиох дор тэд агуу хүчээр номлож, үүний хэрээр тэд нифайчуудыг орхин одсон тэрслэгчдийн олныг нь шившиглэж, үүний хэрээр тэд ирж мөн нүглүүдээ хүлээн мөн наманчлалд хүргэгдэн баптисм хүртэж, мөн тэдний өмнө үйлдсэн буруугаа засахыг чармайн оролдохоор тэр даруй нифайчуудад эргэж ирэв.

18 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар леменчүүдэд тийм агуу хүч хийгээд эрх мэдэлтэйгээр номлож, учир нь тэд ярьж болохын тулд тэдэнд хүч мөн эрх мэдэл өгөгдсөн байв, мөн түүнчлэн тэдний ярих ёстой зүйл тэдэнд өгөгдсөн байв—

19 Тиймийн тул тэд леменчүүдийн агуу гайхал бахдалыг төрүүлэн, тэднийг итгэтэл нь ярив, үүний хэрээр Зарахемла мөн эргэн тойрны нутагт леменчүүдээс найман мянга нь наманчлалд хүргэгдэн баптисм хүртэж, мөн эцэг өвгөдийнхөө уламжлалын ёс бусад итгүүлэгдэв.

20 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар тэндээс Нифайн нутаг тийш аянаа үргэлжлүүлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд леменчүүдийн их цэрэгт баривчлагдаж мөн шоронд; тийм ээ, бүр Лимхайн зарц нараар Аммон болон түүний ах дүүсийн хаягдсан тэрхүү шоронд хаягдав.

22 Мөн тэд олон хоног шоронд хүнсгүйгээр хаягдсаны дараа, болгоогтун, тэд тэднийг алж болохын тулд тэднийг авахаар шоронд очив.

23 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар гаалаар лугаа адил хүрээлэгдэж, бүр үүний хэрээр тэд түлэгдэх болов уу хэмээн айснаас тэдэнд гар хүрч зүрхэлсэнгүй. Гэсэн хэдий ч, Нифай Лихай нар түлэгдсэнгүй; мөн тэд галын дунд зогсох мэт боловч түлэгдсэнгүй.

And they did remember his words; and therefore they went forth, keeping the commandments of God, to teach the word of God among all the people of Nephi, beginning at the city Bountiful;

And from thenceforth to the city of Gid; and from the city of Gid to the city of Mulek;

And even from one city to another, until they had gone forth among all the people of Nephi who were in the land southward; and from thence into the land of Zarahemla, among the Lamanites.

And it came to pass that they did preach with great power, insomuch that they did confound many of those dissenters who had gone over from the Nephites, insomuch that they came forth and did confess their sins and were baptized unto repentance, and immediately returned to the Nephites to endeavor to repair unto them the wrongs which they had done.

And it came to pass that Nephi and Lehi did preach unto the Lamanites with such great power and authority, for they had power and authority given unto them that they might speak, and they also had what they should speak given unto them—

Therefore they did speak unto the great astonishment of the Lamanites, to the convincing them, insomuch that there were eight thousand of the Lamanites who were in the land of Zarahemla and round about baptized unto repentance, and were convinced of the wickedness of the traditions of their fathers.

And it came to pass that Nephi and Lehi did proceed from thence to go to the land of Nephi.

And it came to pass that they were taken by an army of the Lamanites and cast into prison; yea, even in that same prison in which Ammon and his brethren were cast by the servants of Limhi.

And after they had been cast into prison many days without food, behold, they went forth into the prison to take them that they might slay them.

And it came to pass that Nephi and Lehi were encircled about as if by fire, even insomuch that they durst not lay their hands upon them for fear lest they should be burned. Nevertheless, Nephi and Lehi were not burned; and they were as standing in the midst of fire and were not burned.

- 24 Мөн тэд галан баганаар хүрээлэгдсэнээ, мөн энэ нь өөрсдийг нь түлэхгүй байгааг хараад, тэдний зүрх сэтгэл зоригжив.
- 25 Учир нь тэд леменчүүд тэдэнд гар хүрч зүрхлэхгүй байгааг; бас тэдний дэргэд ирж зүрхлэхгүй байгааг, харин тэд гайхсандаа цочирдон балмагдсан мэт зогсохыг харав.
- 26 Мөнхүү улиран тохиох дор Нифай Лихай нар урагшлан зогсож мөн тэдэнд ярьж эхлэв, өгүүлсэн нь: Бүү ай, учир нь болгоогтун, энэ гайхамшигт зүйлийг та нарт үзүүлсэн нь Бурхан юм, үүнд та нар биднийг алахаар бидэнд гараа хүргэж чадахгүйг та нарт үзүүлж байна.
- 27 Мөн болгоогтун, тэд эдгээр үгсийг хэлэхэд газар үлэмж чичирч, мөн шоронгийн хананууд газарт нуран унах гэж байгаа мэтээр чичрэв; гэвч болгоогтун, тэдгээр нь унасангүй. Мөн болгоогтун, шорон дотор байсан тэд леменчүүд мөн тэрслэгчид болох нифайчууд байв.
- 28 Мөнхүү улиран тохиох дор тэд харанхуйн үүлээр сүүдэрлэгдэж, мөн аймшигт цочирдом айдас тэдний дээр ирэв.
- 29 Мөнхүү улиран тохиох дор харанхуйн үүлний дээр байсан мэт дуу хоолой ирж, өгүүлсэн нь: Наманчлагтун та нар, наманчлагтун та нар, мөн сайн мэдээг тунхаглуулахаар та нарт миний илгээсэн үйлчлэгчдийг минь устгахыг цаашид бүү эрэлхийлэгтүн.
- 30 Мөнхүү улиран тохиох дор тэд энэ дуу хоолойг дуулаад, мөн энэ нь аянгын дуу бус, бас агуу их хөл үймээний нүргээнт чимээ бус гэдгийг болгоож, гэвч болгоогтун, энэ нь шивнээн байсан мэт төгс зөөлөн тайван дуу хоолой байж, мөн энэ нь сэтгэлийн угт хүртэл нэвтрэх ажгуу—
- 31 Мөн уг дуу хоолой зөөлөн байсан хэдий ч, болгоогтун газар үлэмж чичирч, мөн шоронгийн хананууд, газарт нурах гэж байгаа мэт дахин чичрэв; мөн болгоогтун тэднийг сүүдэрлэсэн, харанхуйн үүл сарнисангүй—

And when they saw that they were encircled about with a pillar of fire, and that it burned them not, their hearts did take courage.

For they saw that the Lamanites durst not lay their hands upon them; neither durst they come near unto them, but stood as if they were struck dumb with amazement.

And it came to pass that Nephi and Lehi did stand forth and began to speak unto them, saying: Fear not, for behold, it is God that has shown unto you this marvelous thing, in the which is shown unto you that ye cannot lay your hands on us to slay us.

And behold, when they had said these words, the earth shook exceedingly, and the walls of the prison did shake as if they were about to tumble to the earth; but behold, they did not fall. And behold, they that were in the prison were Lamanites and Nephites who were dissenters.

And it came to pass that they were overshadowed with a cloud of darkness, and an awful solemn fear came upon them.

And it came to pass that there came a voice as if it were above the cloud of darkness, saying: Repent ye, repent ye, and seek no more to destroy my servants whom I have sent unto you to declare good tidings.

And it came to pass when they heard this voice, and beheld that it was not a voice of thunder, neither was it a voice of a great tumultuous noise, but behold, it was a still voice of perfect mildness, as if it had been a whisper, and it did pierce even to the very soul—

And notwithstanding the mildness of the voice, behold the earth shook exceedingly, and the walls of the prison trembled again, as if it were about to tumble to the earth; and behold the cloud of darkness, which had overshadowed them, did not disperse—

32 Мөн болгоогтун уг дуу хоолой дахин ирж, хэлсэн нь: Наманчлагтун та нар, наманчлагтун та нар, учир нь тэнгэрийн хаант улс ойрхон байна; мөн зарц нарыг минь устгахыг цаашид бүү эрэлхийлэгтүн. Мөнхүү улиран тохиох дор газар дахин чичирч, мөн хананууд доргилоо.

33 Мөн түүнчлэн дахин гурав дахь удаагаа дуу хоолой ирж, мөн хүмүүнээр хэлэгдэх аргагүй гайхамшигт үгсийг тэдэнд ярьсан болой; мөн хананууд дахин доргиж, мөн газар хэдэн хэсэг хуваагдах гэж байгаа мэт чичрэв.

34 Мөнхүү улиран тохиох дор тэднийг сүүдэрлэх харанхуйн үүлсийн учир леменчүүд зугтаж чадсангүй; тийм ээ, мөн түүнчлэн тэдний дээр ирсэн айдсын учир хөдөлгөөнгүй байв.

35 Эдүгээ тэдний дунд нэгэнтээ Бурханы сүмд харьяалагдаж асан, гэвч тэднээс тэрсэлсэн уг гарал нь нифай үндэстэн болох нэгэн байв.

36 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эргэж, мөн болгоогтун, тэрээр харанхуйн үүлэн дундаас Нифай, Лихай хоёрын царайг харав; мөн болгоогтун, бүр тэнгэр элчүүдийн царай мэт, тэднийх ч үлэмж туяарч байв. Мөн тэд мэлмийгээ тэнгэрт хандуулан өргөснийг тэрээр болгоов; мөн тэд өөрсдийн болгоох ямар нэгэн биетэй дуугаа өргөн өөрөөр хэлбэл ярьж буй маягтай байв.

37 Мөнхүү улиран тохиох дор энэ хүн, тэд эргэж мөн харж болохын тулд цугласан олны зүг хашгирав. Мөн болгоогтун, тэд эргэж мөн харах хүч тэдэнд өгөгдөв; мөн тэд Нифай Лихай хоёрын царайг болгоов.

38 Мөн тэд уг хүнд хэлэв: Болгоогтун, эдгээр бүх зүйл ямар утгатайв, мөн эдгээр эрстэй ярилцах тэр нь хэн билээ

39 Эдүгээ уг хүний нэр Аминадаб байв. Мөн Аминадаб тэдэнд хэлэв: Тэд Бурханы тэнгэр элчүүдтэй ярилцаж байна.

40 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд түүнд хэлэв: Энэ харанхуйн үүл биднийг сүүдэрлэхээ больж, нүүхийн тулд бид юу хийх билээ

And behold the voice came again, saying: Repent ye, repent ye, for the kingdom of heaven is at hand; and seek no more to destroy my servants. And it came to pass that the earth shook again, and the walls trembled.

And also again the third time the voice came, and did speak unto them marvelous words which cannot be uttered by man; and the walls did tremble again, and the earth shook as if it were about to divide asunder.

And it came to pass that the Lamanites could not flee because of the cloud of darkness which did overshadow them; yea, and also they were immovable because of the fear which did come upon them.

Now there was one among them who was a Nephite by birth, who had once belonged to the church of God but had dissented from them.

And it came to pass that he turned him about, and behold, he saw through the cloud of darkness the faces of Nephi and Lehi; and behold, they did shine exceedingly, even as the faces of angels. And he beheld that they did lift their eyes to heaven; and they were in the attitude as if talking or lifting their voices to some being whom they beheld.

And it came to pass that this man did cry unto the multitude, that they might turn and look. And behold, there was power given unto them that they did turn and look; and they did behold the faces of Nephi and Lehi.

And they said unto the man: Behold, what do all these things mean, and who is it with whom these men do converse?

Now the man's name was Aminadab. And Aminadab said unto them: They do converse with the angels of God.

And it came to pass that the Lamanites said unto him: What shall we do, that this cloud of darkness may be removed from overshadowing us?

41 Мөн Аминадаб тэдэнд хэлэв: Та нар наманчилж, бүр Алмагаар, мөн Амюлек хийгээд Зиезромоор та нарт тухайлан сургагдсан тэрхүү Христэд итгэлтэй болох хүртлээ уг дуу хоолойноос гуйх ёстой; мөн та нар үүнийг хийхэд, харанхуйн үүл та нарыг сүүдэрлэхээ больж нүүх болно.

42 Мөнхүү улиран тохиох дор газрыг чичиргэж асан түүний дуу хоолойнд тэд бүгд залбиран гуйж эхлэв; тийм ээ, тэд бүр харанхуйн үүлс сарнис хүртэл гуйв.

43 Мөнхүү улиран тохиох дор тэд нүд гүйлгэн хараад, мөн харанхуйн үүл тэднийг сүүдэрлэхээ болино сарнисныг үзээд, болгоогтун, тийм ээ, бодгаль болгон галан баганаар хүрээлэгдсэн байснаа тэд үзэв.

44 Мөн Нифай, Лихай хоёр тэдний дунд байв; тийм ээ, тэд хүрээлэгдэв; тийм ээ, тэд дүрэлзэх галын дунд буй мэт байв, гэсэн ч энэ нь тэднийг гэмтээсэнгүй, бас шоронгийн ханыг шатаасангүй; мөн тэд алдар суугаар дүүрэн мөн үгээр хэлэхийн аргагүй баяслаар дүүргэгдэв.

45 Мөн болгоогтун, Бурханы Ариун Сүнс тэнгэрээс доош ирж, мөн тэдний зүрх сэтгэлийг эзэмдэв, мөн тэд галаар дүүргэгдсэн лугаа адил болж, мөн тэд гайхамшигт үгсийг ярьж чадав.

46 Мөнхүү улиран тохиох дор нэгэн дуу хоолой тэдэнд ирж, тийм ээ, шивнээн лугаа адил тааламжит дуу хоолой өгүүлсэн нь:

47 Амар амгалан, амар амгалан та нарт байг, дэлхийн үүслээс байсан Ихэд Хайрлагдсанд минь итгэсэн та нарын итгэлийн учир бөлгөө.

48 Мөн эдүгээ, тэд үүнийг сонсоод сайхь дуу хоолой хаанаас ирснийг болгоох гэсэн мэт нүдээ өргөв; мөн болгоогтун, тэд тэнгэр нээгдэхийг үзэв; мөн тэнгэрээс тэнгэр элчүүд бууж ирээд мөн тэдэнд тохинуулав.

49 Мөн эдгээр зүйлийг харж мөн сонссон гурван зуу орчим бодгаль байв; мөн тэд одож мөн эс гайхаж, бас үл эргэлзсэн нь тушаагдав.

50 Мөнхүү улиран тохиох дор тэд одож, мөн эргэн тойрны бүх бүс нутаг даяар өөрсдийн сонссон мөн үзсэн бүх зүйлийг тунхагласаар, хүмүүст тохинуулж, үүний хэрээр леменчүүдийн ихэнх хэсэг, өөрсдийнхөө хүлээж авсан нотолгоонуудын агуу ихийн учир тэднээр итгүүлэгдэв.

And Aminadab said unto them: You must repent, and cry unto the voice, even until ye shall have faith in Christ, who was taught unto you by Alma, and Amulek, and Zeezrom; and when ye shall do this, the cloud of darkness shall be removed from overshadowing you.

And it came to pass that they all did begin to cry unto the voice of him who had shaken the earth; yea, they did cry even until the cloud of darkness was dispersed.

And it came to pass that when they cast their eyes about, and saw that the cloud of darkness was dispersed from overshadowing them, behold, they saw that they were encircled about, yea every soul, by a pillar of fire.

And Nephi and Lehi were in the midst of them; yea, they were encircled about; yea, they were as if in the midst of a flaming fire, yet it did harm them not, neither did it take hold upon the walls of the prison; and they were filled with that joy which is unspeakable and full of glory.

And behold, the Holy Spirit of God did come down from heaven, and did enter into their hearts, and they were filled as if with fire, and they could speak forth marvelous words.

And it came to pass that there came a voice unto them, yea, a pleasant voice, as if it were a whisper, saying:

Peace, peace be unto you, because of your faith in my Well Beloved, who was from the foundation of the world.

And now, when they heard this they cast up their eyes as if to behold from whence the voice came; and behold, they saw the heavens open; and angels came down out of heaven and ministered unto them.

And there were about three hundred souls who saw and heard these things; and they were bidden to go forth and marvel not, neither should they doubt.

And it came to pass that they did go forth, and did minister unto the people, declaring throughout all the regions round about all the things which they had heard and seen, insomuch that the more part of the Lamanites were convinced of them, because of the greatness of the evidences which they had received.



51 Мөн итгүүлэгдсэн болгон нь дайны зэр зэвсгүүдээ,  
мөн түүнчлэн эцэг өвгөдийнхөө үзэн ядалт хийгээд  
уламжлалыг орхив.

52 Мөнхүү улиран тохиох дор эзэмшлийнх нь нут-  
гуудыг нифайчуудад тэд өгөв.

And as many as were convinced did lay down their  
weapons of war, and also their hatred and the tradition  
of their fathers.

And it came to pass that they did yield up unto the  
Nephites the lands of their possession.

## Хиламан 6

- 1 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаран хоёрдугаар он төгсөхөд, эдгээр бүх зүйл тохиосон байв мөн леменчүүд, тэдний ихэнх хэсэг нь, зөв шударга хүмүүс болцгоосон байлаа, үүний хэрээр тэдний зөв шударга нь, тэдний итгэл дэх чанд байдал хийгээд гуйвшгүй чанарын учир нифайчуудынхаас илүү болсон байв.
- 2 Учир нь болгоогтун, нифайчуудаас хатуурхдаг мөн үл наманчилдаг мөн бузар ёс бус болсон нь олон байв, үүний хэрээр Бурханы үгийг мөн тэдний дунд ирсэн бүх номлолыг мөн бошиглолыг тэд эсэргүүцсэн ажгуу.
- 3 Гэсэн хэдий ч, сүмийн хүмүүс леменчүүдийн хөрвүүлгийн учир, тийм ээ, тэдний дунд байгуулагдсан Бурханы сүмийн учир агуу баяртай байв. Мөн тэд нэг нэгэнтэйгээ дотносон нөхөрлөж, мөн нэг нэгэндээ баясан, мөн агуу баяртай байв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдээс олон нь Зарахемла нутаг уруу ирж, мөн нифайчуудын ард түмэнд өөрсдийн хөрвүүлгийн маягийг тунхаглаж, мөн тэднийг итгэлд хийгээд наманчлалд ухуулав.
- 5 Тийм ээ, олон нь үлэмж агуу хүч чадал мөн эрх мэдлээр номлосноос, тэдний олныг нь, Хурганы мөн Бурханы даруу дагалдагчид байхаар даруу байдлын гүнд хүргэн доош авчрав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор леменчүүдийн олон нь умард нутаг тийш одов; мөн түүнчлэн Нифай Лихай хоёр умард нутаг тийш хүмүүст номлохоор одов. Мөн жаран гуравдугаар он тийн төгсөв.
- 7 Мөн болгоогтун, бүх нутагт амар амгалан байж, үүний хэрээр нифайчуудын эсвээс леменчүүдийн дунд гэдгээс үл хамааран нифайчууд уг нутгийн хүссэн хэсэгтээ очиж байв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд ч түүнчлэн леменчүүдийн дунд эсвээс нифайчуудын дунд гэдгээс үл хамааран хүссэн зүгтээ хаа хамаагүй явж байв; мөн тэд тийн хүслийнхээ дагуу, худалдан авч мөн худалдаж, мөн орлого олж нэг нэгэнтэйгээ чөлөөтэй харьцаж байв.

## Helaman 6

And it came to pass that when the sixty and second year of the reign of the judges had ended, all these things had happened and the Lamanites had become, the more part of them, a righteous people, insomuch that their righteousness did exceed that of the Nephites, because of their firmness and their steadiness in the faith.

For behold, there were many of the Nephites who had become hardened and impenitent and grossly wicked, insomuch that they did reject the word of God and all the preaching and prophesying which did come among them.

Nevertheless, the people of the church did have great joy because of the conversion of the Lamanites, yea, because of the church of God, which had been established among them. And they did fellowship one with another, and did rejoice one with another, and did have great joy.

And it came to pass that many of the Lamanites did come down into the land of Zarahemla, and did declare unto the people of the Nephites the manner of their conversion, and did exhort them to faith and repentance.

Yea, and many did preach with exceedingly great power and authority, unto the bringing down many of them into the depths of humility, to be the humble followers of God and the Lamb.

And it came to pass that many of the Lamanites did go into the land northward; and also Nephi and Lehi went into the land northward, to preach unto the people. And thus ended the sixty and third year.

And behold, there was peace in all the land, insomuch that the Nephites did go into whatsoever part of the land they would, whether among the Nephites or the Lamanites.

And it came to pass that the Lamanites did also go whithersoever they would, whether it were among the Lamanites or among the Nephites; and thus they did have free intercourse one with another, to buy and to sell, and to get gain, according to their desire.

- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд, леменчүүд мөн нифайчуудын аль аль нь үлэмж баян болов; мөн үлэмж хангалттай алт, мөн мөнгө, мөн бүх төрлийн үнэт төмөрлөг, өмнөд нутагт мөн умард нутагт аль алинд нь тэдэнд байв.
- 10 Эдүгээ өмнөд нутаг нь Лихай гэж, мөн умард нутаг Зедикаягийн хүүгийн нэрээр Мюлек гэж нэрлэгдэв; учир нь Их Эзэн Мюлекийг умард нутагт, мөн Лихайг өмнөд нутагт авчирсан ажээ.
- 11 Мөн болгоогтун, эдгээр нутагт аль алинд нь зүйл бүрийн алт, мөн мөнгө, мөн төрөл бүрийн үнэт хүдэр байв; мөн бүхий л төрлийн хүдрийг боловсруулж мөн үүнийг цэвэршүүлэх уран дархан ч түүнчлэн байв; мөн тэд тийн баян болсон ажгуу.
- 12 Тэд умард болон өмнөдөд аль алинд нь, үр тариаг элбэгээр ургуулсан болой; мөн умард болон өмнөдөд аль алинд нь тэд үлэмж цэцэглэн хөгжив. Мөн тэд өнөржиж мөн уг нутагт үлэмж хүчтэй болов. Мөн тэд олон бог мал, мөн бод мал, тийм ээ, олон төл мал өсгөсөн болой.
- 13 Болгоогтун эмэгтэйчүүд нь нөр хичээнгүй хөдөлмөрлөж мөн утас ээрч, мөн бүхий л төрлийн даавуу, нарийн нэхээст эд мөн даавууны төрөл бүрийг нүцгэн биесээ хувцаслахаар хийв. Мөн жаран дөрөв дэх он амар амгаланд тийн улирч одов.
- 14 Мөн жаран тав дахь онд түүнчлэн агуу баясал мөн амар амгалан, тийм ээ, ирэх зүйлийн талаар их номлол мөн олон бошиглол тэдэнд байв. Мөн жаран тав дахь он тийн улирч одов.
- 15 Мөнхүү улиран тохиох дор шүүгчдийн засаглалын жаранзургадугаар онд, болгоогтун, Сизром шүүлтийн суудалд сууж байх үед, тэрээр үл мэдэгдэх гарт өртөж алагдав. Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд, түүний хүү, хүмүүсээр түүний оронд тохоогдсон тэр нь, түүнчлэн алагдав. Мөн жаран зургадугаар он тийн төгсөв.
- 16 Мөн жаран долдугаар оны эхэнд хүмүүс дахин үлэмж ёс бус болж эхлэв.

And it came to pass that they became exceedingly rich, both the Lamanites and the Nephites; and they did have an exceeding plenty of gold, and of silver, and of all manner of precious metals, both in the land south and in the land north.

Now the land south was called Lehi, and the land north was called Mulek, which was after the son of Zedekiah; for the Lord did bring Mulek into the land north, and Lehi into the land south.

And behold, there was all manner of gold in both these lands, and of silver, and of precious ore of every kind; and there were also curious workmen, who did work all kinds of ore and did refine it; and thus they did become rich.

They did raise grain in abundance, both in the north and in the south; and they did flourish exceedingly, both in the north and in the south. And they did multiply and wax exceedingly strong in the land. And they did raise many flocks and herds, yea, many fatlings.

Behold their women did toil and spin, and did make all manner of cloth, of fine-twined linen and cloth of every kind, to clothe their nakedness. And thus the sixty and fourth year did pass away in peace.

And in the sixty and fifth year they did also have great joy and peace, yea, much preaching and many prophecies concerning that which was to come. And thus passed away the sixty and fifth year.

And it came to pass that in the sixty and sixth year of the reign of the judges, behold, Cezoram was murdered by an unknown hand as he sat upon the judgment-seat. And it came to pass that in the same year, that his son, who had been appointed by the people in his stead, was also murdered. And thus ended the sixty and sixth year.

And in the commencement of the sixty and seventh year the people began to grow exceedingly wicked again.

17 Учир нь болгоогтун, Их Эзэн тэднийг дэлхийн баялгуудаар урт удаан хугацаанд адисалсан учир тэд уурлахаар, дайтахаар, бас цус урсгахаар өдөөгдөөгүй байжээ; тиймийн тул тэд зүрх сэтгэлээ баялгууд дээрээ тавьж эхлэв; тийм ээ, тэд нэг нь нөгөөгийнхөө дээр гарч болохын тулд тэд хөрөнгөжихийг эрэлхийлж эхлэв; тиймийн тул тэд хөрөнгөжиж болохын тулд тэд нууц аллагууд үйлдэж, мөн дээрэмдэж мөн тонож эхлэв.

18 Мөн эдүгээ болгоогтун, тэдгээр алуурчид хийгээд тонуулчид Кишкумен болон Гадиантоноор байгуулагдсан нэгэн бүлэглэл болов. Мөн эдүгээ улиран тохиох дор Гадиантоны бүлэглэлээс олон нь, бүр нифайчуудын дунд байв. Гэвч болгоогтун, леменчүүдийн илүү ёс бус хэсгийн дунд тэд илүү олон тоотой байв. Мөн тэд Гадиантоны дээрэмчид, алуурчид хэмээн нэрлэгдэв.

19 Мөн ерөнхий шүүгч Сизром, мөн түүний хүүг, шүүлтийн суудалд байхад алсан нь тэд байв; мөн болгоогтун, тэд олж илрүүлэгдээгүй ажээ.

20 Мөн эдүгээ улиран тохиох дор тэдний дунд дээрэмчид байсныг олж мэдээд леменчүүд үлэмж харамсав, мөн тэднийг газрын гадаргуу дээрээс арилган устгаж болохын тул тэд хүч хүрэх арга бүрийг хэрэглэв.

21 Гэвч болгоогтун, нифайчуудын ихэнх хэсгийнх нь зүрх сэтгэлийг Сатан өдөөж, үүний хэрээр тэд дээрэмчдийн бүлэглэлтэй нэгдэж, мөн тэд нэг нэгнээ ямар ч хэцүү нөхцөл байдалд орсон байсан, тэд аллагууд, мөн тонуулууд мөн хулгайнуудынхаа төлөө шийтгэгдэхгүйн тулд тэднийг хаацайлан мөн хамгаална хэмээн тэдний гэрээ болон тангарагт нь оров.

22 Мөнхүү улиран тохиох дор тэд дохионууд, тийм ээ, нууц дохионууд, мөн нууц үгстэй байв; тэд гэрээнд орсон ах дүүсээ ялгаж болохын тулд эдгээр нь байв, тиймээс ах дүүс нь ямар ч ёс бусыг үйлдсэн, ах дүүсээрээ, бас энэхүү гэрээг авсан түүний бүлэглэлд харьяалагдах тэднээр гэмтээгдэхгүйн тулд буюу.

23 Мөн тэгснээр улс орныхоо хуулиудын мөн түүнчлэн Бурханыхаа хуулиудын эсрэг, тэд алж, мөн тонож, мөн хулгайлж, мөн садар самуун мөн бүхий л төрлийн ёс бусыг үйлдэх боломжтой болсон ажгуу.

For behold, the Lord had blessed them so long with the riches of the world that they had not been stirred up to anger, to wars, nor to bloodshed; therefore they began to set their hearts upon their riches; yea, they began to seek to get gain that they might be lifted up one above another; therefore they began to commit secret murders, and to rob and to plunder, that they might get gain.

And now behold, those murderers and plunderers were a band who had been formed by Kishkumen and Gadianton. And now it had come to pass that there were many, even among the Nephites, of Gadianton's band. But behold, they were more numerous among the more wicked part of the Lamanites. And they were called Gadianton's robbers and murderers.

And it was they who did murder the chief judge Cezoram, and his son, while in the judgment-seat; and behold, they were not found.

And now it came to pass that when the Lamanites found that there were robbers among them they were exceedingly sorrowful; and they did use every means in their power to destroy them off the face of the earth.

But behold, Satan did stir up the hearts of the more part of the Nephites, insomuch that they did unite with those bands of robbers, and did enter into their covenants and their oaths, that they would protect and preserve one another in whatsoever difficult circumstances they should be placed, that they should not suffer for their murders, and their plunderings, and their stealings.

And it came to pass that they did have their signs, yea, their secret signs, and their secret words; and this that they might distinguish a brother who had entered into the covenant, that whatsoever wickedness his brother should do he should not be injured by his brother, nor by those who did belong to his band, who had taken this covenant.

And thus they might murder, and plunder, and steal, and commit whoredoms and all manner of wickedness, contrary to the laws of their country and also the laws of their God.

- 24 Мөн тэдний бүлэглэлд харьяалагдсан тэднээс ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнхээ талаар дэлхийд илчлэх хэн боловч, улсынхаа хуулиудын дагуу бус, харин Гадиянтон болон Кишкуменээр өгөгдсөн, өөрсдийн ёс бус хуулиудын дагуу шүүгдэх болно.
- 25 Эдүгээ болгоогтун, тэд хүмүүсийг доош устгалд авчрах хэрэгсэл болуузай хэмээн айж, дэлхийд одох хэрэггүй хэмээн Алма хүүдээ зарлигласан нууц тангаргууд мөн гэрээнүүд нь эдгээр бөлгөө.
- 26 Эдүгээ болгоогтун, тэдгээр нууц тангаргууд мөн гэрээнүүд нь Хиламанд хүргэгдсэн цэдгүүдээс Гадиянтонд ирээгүй; гэвч болгоогтун, тэдгээр нь бидний анхны эцэг эхийг хориглогдсон жимснээс хүртэхэд уруу татсан тэрхүү нэгэн биеэр Гадиянтоны зүрх сэтгэлд мэдүүлэгдсэн бөлгөө—
- 27 Тийм ээ, хэрэв тэрбээр дүү Абелаа алах аваас энэ нь дэлхийд мэдэгдэхгүй хэмээн Каинтай хуйвалдсан тэрхүү бие билээ. Мөн тэр цагаас хойш тэрбээр Каин болон түүний дагалдагсадтай хуйвалдсаар ирсэн билээ.
- 28 Мөн тэд тэнгэрт хүрч болох хангалттай өндөр цамхаг барих бодлыг хүмүүсийн зүрх сэтгэлд төрүүлсэн нь түүнчлэн тэрхүү бие бөлгөө. Мөн уг цамхгаас энэ нутагт ирсэн тэр хүмүүсийг удирдсан нь; хүмүүсийг бүрмөсөн сүйрэх устгалд, мөн үүрдийн тамд чирэн оруултал харанхуйн ажлыг мөн жигшүүрт хэргүүдийг бүх нутгийн гадаргуугаар нэг тараасан нь тэрхүү бие билээ.
- 29 Тийм ээ, харанхуйн мөн нууц аллагын ажлыг үргэлжлүүлсээр байх бодлыг Гадиянтоны зүрх сэтгэлд төрүүлсэн нь тэрхүү бие; мөн тэрээр энэ ажлыг хүмүүний эхлэлээс бүр энэ цагийг хүртэл авчирсан юм.
- 30 Мөн болгоогтун, бүх нүглийг үүсгэгч нь тэр болой. Мөн болгоогтун, хүмүүний үрсийн зүрх сэтгэлд нөлөө олж чадсаныхаа хэрээр тэрбээр өөрийн харанхуйн мөн нууц аллагын ажлыг үргэлжлүүлж, мөн тэдний хуйвалдаанууд, мөн тангаргууд, мөн гэрээнүүд, мөн аймшигт ёс бус төлөвлөгөөнүүдийг нь үеэс үед гардуулан өгдөг.

And whosoever of those who belonged to their band should reveal unto the world of their wickedness and their abominations, should be tried, not according to the laws of their country, but according to the laws of their wickedness, which had been given by Gadianton and Kishkumen.

Now behold, it is these secret oaths and covenants which Alma commanded his son should not go forth unto the world, lest they should be a means of bringing down the people unto destruction.

Now behold, those secret oaths and covenants did not come forth unto Gadianton from the records which were delivered unto Helaman; but behold, they were put into the heart of Gadianton by that same being who did entice our first parents to partake of the forbidden fruit—

Yea, that same being who did plot with Cain, that if he would murder his brother Abel it should not be known unto the world. And he did plot with Cain and his followers from that time forth.

And also it is that same being who put it into the hearts of the people to build a tower sufficiently high that they might get to heaven. And it was that same being who led on the people who came from that tower into this land; who spread the works of darkness and abominations over all the face of the land, until he dragged the people down to an entire destruction, and to an everlasting hell.

Yea, it is that same being who put it into the heart of Gadianton to still carry on the work of darkness, and of secret murder; and he has brought it forth from the beginning of man even down to this time.

And behold, it is he who is the author of all sin. And behold, he doth carry on his works of darkness and secret murder, and doth hand down their plots, and their oaths, and their covenants, and their plans of awful wickedness, from generation to generation according as he can get hold upon the hearts of the children of men.

- 31 Мөн эдүгээ болгоогтун, нифайчуудын зүрх сэтгэлд агуу нөлөөг олж; тийм ээ, үүний хэрээр тэд үлэмж ёс бус болсон байв; тийм ээ, тэдний ихэнх хэсэг нь зөв шударга замыг орхисон байв, мөн Бурханы зарлигуудыг хөл дороо дэвсэлж, мөн өөрсдийн замуудыг хөөж, мөн алт болон мөнгөөрөө өөрсөддөө шүтээнүүдийг босгосон ажээ.
- 32 Мөнхүү улиран тохиох дор цөөн жилийн хугацаанд тэдний дээр эдгээр бүх алдсууд ирж, үүний хэрээр Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын жаран долдугаар онд эдгээрийн ихэнх хэсэг нь тэдний дээр ирсэн байв.
- 33 Мөн жаран найм дахь онд ч түүнчлэн, зөв шударгыг үйлдэгсдийн агуу харамсал хийгээд гашуудлыг төрүүлж, тэд алдсууддаа улам автаж байв.
- 34 Мөн нифайчууд итгэлгүйдээ бууран доройтож, леменчүүд Бурханыхаа мэдлэгт үлэмж өсөж эхэлсэн тэр үед тэд, мөн ёс бусад мөн жигшүүрт хэргүүдэд автагдаж эхэлснийг бид ийн үзлээ; тийм ээ, тэд түүний дүрмүүдийг мөн зарлигуудыг дагаж, мөн түүний өмнө зөвөөр мөн үнэнээр алхаж эхлэв.
- 35 Мөн зүрх сэтгэлийнх нь ёс бус хийгээд хатуугийн учир, Их Эзэний Сүнс нифайчуудаас холдож эхэлснийг бид ийн үзлээ.
- 36 Мөн тэдний үгсэд амархнаар мөн дуртайяа итгэсний учир леменчүүдийн дээр Их Эзэн Сүнсээ юүлж эхэлснийг бид тийн үзлээ.
- 37 Мөнхүү улиран тохиох дор Гадантоны дээрэмчдийн бүлэглэлийг леменчүүд мөрдөв; мөн тэдний илүү ёс бус хэсгийн дунд Бурханы үгийг тэд номлосон аж, үүний хэрээр энэхүү дээрэмчдийн бүлэглэл леменчүүдийн дундаас бүрмөсөн устгагдсан байв.
- 38 Мөнхүү улиран тохиох дор нөгөөтэйгүүр, тэдний нууц аллагууд мөн хуйвалдаануудад тэдэнтэй нэгдэхээр, тэдний олзноос хүртэх мөн тэдний ажилд нь итгэх болтол зөв шударгыг үйлдэгчдийн ихэнх хэсгийг мэхлэн дагуулж, нифайчуудын бүх нутаг даяар тархах хүртэл тэдний илүү ёс бус хэсгээс эхлээд нифайчууд тэднийг өөгшүүлж мөн дэмжив.

And now behold, he had got great hold upon the hearts of the Nephites; yea, insomuch that they had become exceedingly wicked; yea, the more part of them had turned out of the way of righteousness, and did trample under their feet the commandments of God, and did turn unto their own ways, and did build up unto themselves idols of their gold and their silver.

And it came to pass that all these iniquities did come unto them in the space of not many years, insomuch that a more part of it had come unto them in the sixty and seventh year of the reign of the judges over the people of Nephi.

And they did grow in their iniquities in the sixty and eighth year also, to the great sorrow and lamentation of the righteous.

And thus we see that the Nephites did begin to dwindle in unbelief, and grow in wickedness and abominations, while the Lamanites began to grow exceedingly in the knowledge of their God; yea, they did begin to keep his statutes and commandments, and to walk in truth and uprightness before him.

And thus we see that the Spirit of the Lord began to withdraw from the Nephites, because of the wickedness and the hardness of their hearts.

And thus we see that the Lord began to pour out his Spirit upon the Lamanites, because of their easiness and willingness to believe in his words.

And it came to pass that the Lamanites did hunt the band of robbers of Gadianton; and they did preach the word of God among the more wicked part of them, insomuch that this band of robbers was utterly destroyed from among the Lamanites.

And it came to pass on the other hand, that the Nephites did build them up and support them, beginning at the more wicked part of them, until they had overspread all the land of the Nephites, and had seduced the more part of the righteous until they had come down to believe in their works and partake of their spoils, and to join with them in their secret murders and combinations.

39 Мөн тэд тийн засгийн газрын цорын ганц удирдлагыг авч, үүний хэрээр тэд ядуу бөгөөд номхон дөлгөөн, мөн Бурханы даруу дагалдагчдыг хөл дороо дэвсэлж мөн цохиж мөн зовоож мөн тэдэнд араа харуулав.

40 Мөн тэд аймшигт байдалд мөн үүрдийн устгалд боловсорч гүйцээд байсныг бид тийн харлаа.

41 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын жаран найм дахь он тийн төгсөв.

And thus they did obtain the sole management of the government, insomuch that they did trample under their feet and smite and rend and turn their backs upon the poor and the meek, and the humble followers of God.

And thus we see that they were in an awful state, and ripening for an everlasting destruction.

And it came to pass that thus ended the sixty and eighth year of the reign of the judges over the people of Nephi.

*Хиламаны хүү Нифайн бошиглол оршвой—Тэд ёс бус үйлүүдээ наманчлахгүй бол тэднийг бүрмөсөн устгалд хүргэн, уур хилэндээ тэдэнд зочлох болно хэмээн Бурхан Нифайн хүмүүст заналхийлэв. Бурхан Нифайн хүмүүсийг тахлаар цохив; тэд наманчилж мөн түүнд хандав. Лемен үндэстэн, Сэмүел нифайчуудад бошиглов.*

## Хиламан 7

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор нифайчуудын хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын жаран есдүгээр онд Хиламаны хүү Нифай умардын нутгаас Зарахемлагийн нутагт эргэж ирэв.
- 2 Учир нь тэрээр умардын нутагт байсан хүмүүсийн дунд явж, мөн Бурханы үгийг тэдэнд номлож, мөн тэдэнд олон зүйлийг бошиглосон бөлгөө;
- 3 Мөн тэд түүний бүх үгсийг эсэргүүцэж, үүний хэрээр тэрээр тэдний дунд үлдэж чадсангүй, харин төрөлх нутагтаа дахин эргэж иржээ.
- 4 Мөн хүмүүс тийм аймшигт ёс бусын байдалд буйг, мөн Гадиантоны дээрэмчид шүүлтийн суудлуудыг—уг нутгийн хүч чадал мөн эрх мэдлийг хууль бусаар булаан эзэлснийг; Бурханы зарлигуудыг хойш тавьж, түүний өмнө өчүүхэн ч зөв шударга байсангүйг; хүмүүний үрсэд зөв шударгыг үйлдсэнгүйг харжээ;
- 5 Зөв шударгынх нь учир зөв шударгыг үйлдэгсдийг буруушаахыг; гэмтнүүдийг мөн ёс бусыг үйлдэгсдийг мөнгөнийх нь учир үл шийтгэн явуулахыг; мөн үүнээс гадна тэд дэлхийгээс нэр алдар хийгээд эд хөрөнгө олж болохын тулд, мөн үүнээс гадна, тэд илүү амархнаар садар самууныг үйлдэж, мөн хулгайлж, мөн алж, мөн өөрсдийнхөө таалалуудын дагуу үйлдэж болохын тулд тааллуудынхаа дагуу удирдаж мөн үйлдэхээр засгийн газрын тэргүүн албанд байхыг буюу—
- 6 Эдүгээ цөөн жилийн дотор энэ агуу алдас нифайчуудын дээр ирэв; мөн Нифай үүнийг хараад, зүрх нь цээжин дотроо харамслаар тэлэв; мөн тэрээр бодгалийн шаналалдаа дуу алдаж:

*THE PROPHECY OF NEPHI, THE SON OF HELAMAN—God threatens the people of Nephi that he will visit them in his anger, to their utter destruction except they repent of their wickedness. God smiteth the people of Nephi with pestilence; they repent and turn unto him. Samuel, a Lamanite, prophesies unto the Nephites.*

## Helaman 7

Behold, now it came to pass in the sixty and ninth year of the reign of the judges over the people of the Nephites, that Nephi, the son of Helaman, returned to the land of Zarahemla from the land northward.

For he had been forth among the people who were in the land northward, and did preach the word of God unto them, and did prophesy many things unto them;

And they did reject all his words, insomuch that he could not stay among them, but returned again unto the land of his nativity.

And seeing the people in a state of such awful wickedness, and those Gadianton robbers filling the judgment-seats—having usurped the power and authority of the land; laying aside the commandments of God, and not in the least aright before him; doing no justice unto the children of men;

Condemning the righteous because of their righteousness; letting the guilty and the wicked go unpunished because of their money; and moreover to be held in office at the head of government, to rule and do according to their wills, that they might get gain and glory of the world, and, moreover, that they might the more easily commit adultery, and steal, and kill, and do according to their own wills—

Now this great iniquity had come upon the Nephites, in the space of not many years; and when Nephi saw it, his heart was swollen with sorrow within his breast; and he did exclaim in the agony of his soul:



7 Ай, би түүнтэй хамт амлагдсан нутагт баясаж чадахын тулд өөрийн өвөг Нифай анх Иерусалим нутгаас гарах үед өөрийн өдрүүдийг өнгөрөөсөн болоосой би; тэгэхэд түүний хүмүүс анхаарлаа амархан хандуулдаг байж, Бурханы зарлигуудыг дагахдаа чанд, мөн алдсыг үйлдэхээр удирдагдахдаа удаан байжээ; мөн тэд Их Эзэний үгсийг дуулахдаа хурдан байжээ—

8 Тийм ээ, хэрэв миний өдрүүд тэдгээр өдрүүдэд байх боломжтой байсан аваас, ах дүүсийнхээ зөв шударгын учир бодгаль минь баясахсан билээ.

9 Гэвч болгоогтун, эдгээр нь миний өдрүүд байх нь, мөн ах дүүсийнхээ энэ ёс бусын учир бодгаль минь харамслаар дүүргэгдэх нь надад заяагдсан ажээ.

10 Мөн болгоогтун, эдүгээ улиран тохиох дор энэ нь Зарахемлагийн хотод байсан, төв зах тийш хүрэх тэр их хөлийн замын дэргэдэх, Нифайн цэцэрлэгт байсан нэгэн цамхаг дээр байв; тиймийн тул, түүнчлэн их хөлийн зам дэргэдүүр нь өнгөрөх цэцэрлэгийн хаалганы ойролцоо байсан цамхаг болох, өөрийн цэцэрлэг доторх тэрхүү цамхаг дээр Нифай өөрөө бөхийн суув.

11 Мөнхүү улиран тохиох дор цамхаг дээр Нифай Бурханд сэтгэлээ юүлж байхад хажуугаар өнгөрч мөн харсан хэдэн хүмүүн байв; мөн тэд гүйж мөн үзсэнээ хүмүүст хэлэв, мөн хүмүүсийн ёс бусын төлөө тийм агуу гашуудлын шалтгааныг мэдэж болохын тулд хүмүүс бөөн бөөнөөрөө цуглан ирэв.

12 Мөн эдүгээ, Нифай босохдоо тэрээр нэгдэн цугларсан хүмүүс бөөгнөрснийг болгоов.

13 Мөнхүү улиран тохиох дор тэрээр амаа нээж мөн тэдэнд хэлэв: Болгоогтун, та нар яагаад өөрсдөө нэгдэн цугларцгаасан билээ? Би өөрсдийн чинь алдсуудыг хэлж болохын тулд гэж үү

14 Тийм ээ, би Бурхандаа сэтгэлээ юүлж болохын тулд цамхаг дээр гарсны учир нь, та нарын алдсуудын учир зүрх сэтгэлийн минь үлэмжийн их харамлын учир бөлгөө!

15 Мөн гашуудал мөн гаслангийн минь учир та нар нэгдэн цуглараад, мөн гайхаж байна; тийм ээ, мөн та нарт гайхах их хэрэгцээ буй; тийм ээ, та нар бууж өгснөөр чөтгөр та нарын зүрх сэтгэлд агуу байрыг эзэлсэн учир та нар гайхвал зохино.

Oh, that I could have had my days in the days when my father Nephi first came out of the land of Jerusalem, that I could have joyed with him in the promised land; then were his people easy to be entreated, firm to keep the commandments of God, and slow to be led to do iniquity; and they were quick to hearken unto the words of the Lord—

Yea, if my days could have been in those days, then would my soul have had joy in the righteousness of my brethren.

But behold, I am consigned that these are my days, and that my soul shall be filled with sorrow because of this the wickedness of my brethren.

And behold, now it came to pass that it was upon a tower, which was in the garden of Nephi, which was by the highway which led to the chief market, which was in the city of Zarahemla; therefore, Nephi had bowed himself upon the tower which was in his garden, which tower was also near unto the garden gate by which led the highway.

And it came to pass that there were certain men passing by and saw Nephi as he was pouring out his soul unto God upon the tower; and they ran and told the people what they had seen, and the people came together in multitudes that they might know the cause of so great mourning for the wickedness of the people.

And now, when Nephi arose he beheld the multitudes of people who had gathered together.

And it came to pass that he opened his mouth and said unto them: Behold, why have ye gathered yourselves together? That I may tell you of your iniquities?

Yea, because I have got upon my tower that I might pour out my soul unto my God, because of the exceeding sorrow of my heart, which is because of your iniquities!

And because of my mourning and lamentation ye have gathered yourselves together, and do marvel; yea, and ye have great need to marvel; yea, ye ought to marvel because ye are given away that the devil has got so great hold upon your hearts.

16 Тийм ээ, та нарын бодгалийг үүрдийн аймшиг мөн төгсгөлгүй халаглалд доош чулуудахаар эрэлхийлж буй түүний уруу таталтанд та нар хэрхэн бууж өгч яаж чадна вэ

17 Ай наманчлагтун та нар, наманчлагтун та нар! Та нар яагаад үхэх билээ? Та нар эргэ, та нар Их Эзэн Бурханыхаа зүг эргэ. Тэрбээр яагаад та нарыг орхисон билээ

18 Энэ нь та нар зүрх сэтгэлээ хатууруулсных бөлгөө; тийм ээ, та нар сайн хоньчны дуу хоолойг анхааран сонсоогүй; тийм ээ, та нар өөрсдийнхөө эсрэг уурлуулахаар түүнийг өдөөн хатгасан билээ.

19 Мөн болгоогтун, та нарыг цуглуулахын оронд, та нар наманчлахгүй аваас, болгоогтун, тэрээр та нарыг тарааснаар та нар нохдын хийгээд зэрлэг араатнуудын идэш байх болно.

20 Ай, тэрбээр та нарыг чөлөөлсөн чухам тэрхүү өдөр та нар Бурханаа хэрхэн мартаж чадсан бэ

21 Гэвч болгоогтун, энэ нь эд хөрөнгө олохын тулд, хүмүүнээр магтуулахын тулд, тийм ээ, та нар алт болон мөнгө авч болохын тулд болой. Мөн та нар зүрх сэтгэлээ энэ дэлхийн баялгууд хийгээд хоосон зүйлүүд дээр байрлуулсан, үүнийхээ төлөө та нар алж, мөн тонож, мөн хулгайлж, мөн хөршийнхөө эсрэг хуурамчаар гэрчилдэг, мөн бүхий л төрлийн алдсуудыг үйлддэг.

22 Мөн энэ шалтгааны учир, та нар наманчлахгүй аваас та нарын дээр халаг ирэх болно. Учир нь хэрэв та нар наманчлахгүй аваас, болгоогтун, энэ их хот, мөн түүнчлэн эргэн тойрон дахь бидний эзэмшлийн нутагт буй тэдгээр бүх агуу хотууд, та нар тэдний дотор байргүй байхын тулд булаан эзлэгдэх болно; учир нь болгоогтун, Их Эзэн эдүгээ хүртэл хийснийхээ адилаар, дайснуудаа сөрөн зогсох хүчийг та нар төгөхгүй.

23 Учир нь болгоогтун, Их Эзэн тийн хэлэв: Нүглүүдээ наманчилж, мөн үгсийг минь анхааран сонссон тэднээс бусдад бол, ёсон бусыг үйлдэгчдийг нэгийг нь нөгөөгөөс илүүд үзэж өөрийн хүчнээсээ үзүүлэхгүй. Эдүгээ тиймийн тул, ах дүүс минь, та нар наманчлахаас бусдаар та нарыг бодвол леменчүүдэд илүү дээр байх болно гэдгийг та нар болгоогоосой хэмээнэ би.

Yea, how could you have given way to the enticing of him who is seeking to hurl away your souls down to everlasting misery and endless wo?

O repent ye, repent ye! Why will ye die? Turn ye, turn ye unto the Lord your God. Why has he forsaken you?

It is because you have hardened your hearts; yea, ye will not hearken unto the voice of the good shepherd; yea, ye have provoked him to anger against you.

And behold, instead of gathering you, except ye will repent, behold, he shall scatter you forth that ye shall become meat for dogs and wild beasts.

O, how could you have forgotten your God in the very day that he has delivered you?

But behold, it is to get gain, to be praised of men, yea, and that ye might get gold and silver. And ye have set your hearts upon the riches and the vain things of this world, for the which ye do murder, and plunder, and steal, and bear false witness against your neighbor, and do all manner of iniquity.

And for this cause wo shall come unto you except ye shall repent. For if ye will not repent, behold, this great city, and also all those great cities which are round about, which are in the land of our possession, shall be taken away that ye shall have no place in them; for behold, the Lord will not grant unto you strength, as he has hitherto done, to withstand against your enemies.

For behold, thus saith the Lord: I will not show unto the wicked of my strength, to one more than the other, save it be unto those who repent of their sins, and hearken unto my words. Now therefore, I would that ye should behold, my brethren, that it shall be better for the Lamanites than for you except ye shall repent.

- 24 Учир нь болгоогтун, тэд та нараас илүү зөв шударга, учир нь тэд та нарын хүлээн авсан тэр агуу мэдлэгийн эсрэг нүгэл үйлдээгүй; тиймийн тул Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй байх болно; тийм ээ, тэр ч байтугай та нар наманчлахгүй аваас бүрмөсөн устгагдах үед ч тэрээр тэдний өдрүүдийг уртасгаж мөн үр удмыг нь өсгөх болно.
- 25 Тийм ээ, та нарын дунд ирсэн агуу жигшүүрт байдлын учир та нарт халаг болог; мөн та нар өөрсдийгөө үүнд, тийм ээ, Гадантоноор байгуулагдсан нууц бүлэглэлд нэгтгэсэн!
- 26 Тийм ээ, та нар зүрх сэтгэлдээ орохыг хүлцсэн, өөрсдийн үлэмж агуу баялгуудын учир сайнаас хэтрүүлэн хэт хөөргөсөн бардамналын учир та нарт халаг ирэх болно!
- 27 Тийм ээ, та нарын ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн чинь учир та нарт халаг байг!
- 28 Мөн та нар наманчлахгүй аваас та нар мөхөх болно; тийм ээ, бүр газар нутгууд чинь та нараас булаан эзлэгдэж, мөн та нар газрын гадаргуу дээрээс устгагдах болно.
- 29 Болгоогтун эдүгээ, эдгээр зүйлүүд байх болно хэмээн би өөрөө мэдээд хэлээгүй, учир нь би эдгээр зүйлийг мэдэж байгаа нь өөрөө бус юм; гэвч болгоогтун, Их Эзэн Бурхан тэдгээрийг надад мэдүүлсэн учир би эдгээр зүйлүүд үнэнийг мэднэ, тиймийн тул тэдгээр нь байх болно хэмээн гэрчилж байна би.

For behold, they are more righteous than you, for they have not sinned against that great knowledge which ye have received; therefore the Lord will be merciful unto them; yea, he will lengthen out their days and increase their seed, even when thou shalt be utterly destroyed except thou shalt repent.

Yea, wo be unto you because of that great abomination which has come among you; and ye have united yourselves unto it, yea, to that secret band which was established by Gadianon!

Yea, wo shall come unto you because of that pride which ye have suffered to enter your hearts, which has lifted you up beyond that which is good because of your exceedingly great riches!

Yea, wo be unto you because of your wickedness and abominations!

And except ye repent ye shall perish; yea, even your lands shall be taken from you, and ye shall be destroyed from off the face of the earth.

Behold now, I do not say that these things shall be, of myself, because it is not of myself that I know these things; but behold, I know that these things are true because the Lord God has made them known unto me, therefore I testify that they shall be.

## Хиламан 8

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Нифай эдгээр үгсийг хэлэхэд, болгоогтун, шүүгчид, түүнчлэн Гадиянтоны нууц бүлэглэлд харьяалагдсан эрс болох тэд уурлаж, мөн тэд түүний эсрэг хашгирч, хүмүүст хэлсэн нь: Та нар яагаад энэ хүнийг тэрээр хийсэн хэргийнхээ дагуу яллагдаж болохын тулд баривчилж мөн түүнийг нааш авчрахгүй байгаа билээ
- 2 Та нар яагаад энэ хүнийг харж, мөн энэ хүмүүсийн эсрэг мөн хуулийн маань эсрэг доромжлохыг нь сонсоно вэ
- 3 Учир нь болгоогтун, Нифай тэдэнд хуулийнх нь гуйвуулгын талаар ярьсан байв; тийм ээ, бичигдэх аргагүй олон зүйлийг Нифай ярьжээ; мөн тэрбээр Бурханы зарлигуудын эсрэг юу ч ярьсангүй.
- 4 Мөн тэдний харанхуйн нууц ажлуудын талаар тэрээр тэдэнд тодорхой ярьсан учир шүүгчид түүнд уурлаж байв; гэсэн хэдий ч, тэд өөрсдөө түүнд гар хүрч зүрхэлсэнгүй, учир нь хүмүүс тэдний эсрэг хашгиралдах болов уу хэмээн тэд айсан ажээ.
- 5 Тиймийн тул тэд хүмүүст хашгирч, хэлсэн нь: Та нар яагаад энэ хүн бидний эсрэг эсэргүүцэн доромжлохыг тэвчнэв? Учир нь болгоогтун тэрээр энэ бүх хүмүүсийг, бүр устгалд буруушааж байна; тийм ээ, мөн түүнчлэн бид тэдний дотор эзлэх байргүй байхын тулд манай их хотууд биднээс булаан авагдах болно.
- 6 Мөн эдүгээ энэ нь боломжгүйг бид мэднэ, учир нь болгоогтун, бид хүчирхэг, мөн хотууд маань агуу, тиймийн тул бидний дайснууд бидний дээр хүчгүй байх болно.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэд Нифайн эсрэг хүмүүсийг уурлуулахаар тийн өдөөж, мөн тэдний дунд зөрчилдөөнүүд үүсгэв; учир нь тэнд байсан зарим нь хашгирч: Энэ хүнийг орхи, учир нь тэрээр сайн хүн, мөн бид наманчлахгүй аваас түүний хэлж буй зүйлүүд гарцаагүй улиран тохиох болно;

## Helaman 8

And now it came to pass that when Nephi had said these words, behold, there were men who were judges, who also belonged to the secret band of Gadianton, and they were angry, and they cried out against him, saying unto the people: Why do ye not seize upon this man and bring him forth, that he may be condemned according to the crime which he has done?

Why seest thou this man, and hearest him revile against this people and against our law?

For behold, Nephi had spoken unto them concerning the corruptness of their law; yea, many things did Nephi speak which cannot be written; and nothing did he speak which was contrary to the commandments of God.

And those judges were angry with him because he spake plainly unto them concerning their secret works of darkness; nevertheless, they durst not lay their own hands upon him, for they feared the people lest they should cry out against them.

Therefore they did cry unto the people, saying: Why do you suffer this man to revile against us? For behold he doth condemn all this people, even unto destruction; yea, and also that these our great cities shall be taken from us, that we shall have no place in them.

And now we know that this is impossible, for behold, we are powerful, and our cities great, therefore our enemies can have no power over us.

And it came to pass that thus they did stir up the people to anger against Nephi, and raised contentions among them; for there were some who did cry out: Let this man alone, for he is a good man, and those things which he saith will surely come to pass except we repent;

- 8 Тийм ээ, болгоогтун, бидэнд түүний гэрчилсэн бүх шийтгэлүүд бидний дээр ирэх болно; учир нь бидний алдсуудын талаар бидэнд тэр зөвөөр гэрчилснийг бид мэднэ. Мөн болгоогтун тэдгээр нь олон, мөн тэрбээр алдсуудыг маань мэддэгийн адил бидэнд тохиох бүх зүйлийг мэддэг бөлгөө.
- 9 Тийм ээ, мөн болгоогтун, хэрэв тэрбээр бошиглогч биш байсан бол тэдгээр зүйлийн талаар гэрчилж чадахгүй байхсан.
- 10 Мөнхүү улиран тохиох дор Нифайг устгахыг эрэлхийлсэн хүмүүс айдсынхаа учир албадуулагдсанаас, тэд түүнд гар хүрч зүрхэлсэнгүй; тиймийн тул заримын нүдэнд таалал олсноо хараад, тэрээр тэдэнд дахин ярьж эхлэв, үүний хэрээр тэднээс бусад нь айсан аж.
- 11 Тиймийн тул тэрээр тэдэнд илүү ихийг ярихаар албадагдаж, хэлсэн нь: Болгоогтун, ах дүүс минь, Бурхан нэгэн хүнд, бүр Мосед, Улаан Тэнгисийн усыг цохих хүчийг өгсөн билээ, мөн тэдгээр нь нааш мөн цааш хуваагдаж, үүний хэрээр бидний эцэг өвгөд асан изриалчууд хуурай газар дээгүүр гарч ирсэн юм, мөн ус нь египетчүүдийн их цэргийн дээр хучин бууж мөн тэднийг залгисныг уншаагүй гэж үү
- 12 Мөн эдүгээ болгоогтун, хэрэв Бурхан энэ хүнд ийм хүч өгсөн байхад, тэгвэл та нар яагаад өөр хоорондоо маргалдаж, мөн та нар наманчлахгүй аваас та нарын дээр ирэх тэр шүүлтүүдийн талаар би мэдэж болох хүчийг тэр надад өгөөгүй хэмээн хэлэх болов
- 13 Гэвч, болгоогтун, та нар зөвхөн миний үгсийг үгүйсгэх биш, харин та нар эцэг өвгөдөөрөө яригдсан бүх үгсийг ч, мөн түүнчлэн энэ хүн болох Мосегийн, тийм агуу хүч өгөгдсөн түүний ярьсан үгсийг ч бас, тийм ээ, Мессиагийн ирэлтийн талаар түүний ярьсан үгсийг ч түүнчлэн үгүйсгэж байгаа хэрэг.
- 14 Тийм ээ, тэрээр Бурханы Хүү ирнэ гэсэн цэдгийг үлдээгээгүй гэж үү? Мөн тэрээр аглаг буйдад гуулин могойг өргөсний адил, түүнчлэн ирэх тэр ч бас өргөгдөх болно.

Yea, behold, all the judgments will come upon us which he has testified unto us; for we know that he has testified aright unto us concerning our iniquities. And behold they are many, and he knoweth as well all things which shall befall us as he knoweth of our iniquities;

Yea, and behold, if he had not been a prophet he could not have testified concerning those things.

And it came to pass that those people who sought to destroy Nephi were compelled because of their fear, that they did not lay their hands on him; therefore he began again to speak unto them, seeing that he had gained favor in the eyes of some, insomuch that the remainder of them did fear.

Therefore he was constrained to speak more unto them saying: Behold, my brethren, have ye not read that God gave power unto one man, even Moses, to smite upon the waters of the Red Sea, and they parted hither and thither, insomuch that the Israelites, who were our fathers, came through upon dry ground, and the waters closed upon the armies of the Egyptians and swallowed them up?

And now behold, if God gave unto this man such power, then why should ye dispute among yourselves, and say that he hath given unto me no power whereby I may know concerning the judgments that shall come upon you except ye repent?

But, behold, ye not only deny my words, but ye also deny all the words which have been spoken by our fathers, and also the words which were spoken by this man, Moses, who had such great power given unto him, yea, the words which he hath spoken concerning the coming of the Messiah.

Yea, did he not bear record that the Son of God should come? And as he lifted up the brazen serpent in the wilderness, even so shall he be lifted up who should come.

- 15 Мөн тэрхүү могойг харсан болгон амьдрах байсны адил, тэрчлэн Бурханы Хүүг итгэлтэйгээр мөн гэмшсэн сэтгэлтэйгээр харсан болгон, бүр мөнхийн болох тэрхүү амьдралаар амьдарч болох бөлгөө.
- 16 Мөн эдүгээ болгоогтун, ганцхан Мосе бус, харин түүнчлэн түүний өдрүүдээс бүр Абрахамын өдрүүдийг хүртэлх бүх ариун бошиглогчид эдгээр зүйлийг гэрчилсэн юм.
- 17 Тийм ээ, мөн болгоогтун, Абрахам түүний ирэлтийг харж, мөн баяр талархлаар дүүргэгдэж, баяссан юм.
- 18 Тийм ээ, мөн болгоогтун би та нарт хэлье, зөвхөн Абрахам эдгээр зүйлийн тухай мэдсэн юм биш, харин Абрахамын өдрүүдээс өмнө Бурханы жаягаар дуудагдсан нь олон бөлгөө; тийм ээ, бүр түүний Хүүгийн жаягаар; мөн түүний ирэлтээс олон мянган жилийн өмнө ч, тэр ч байтугай гэтэлгэл тэдэнд ирэх болно гэдэг нь хүмүүст үзүүлэгдэж болохын тулд энэ нь байсан болой.
- 19 Мөн эдүгээ бүр Абрахамын өдрүүдээс хойш эдгээр зүйлийг гэрчилсэн олон бошиглогч байсныг та нар мэдээсэй хэмээнэ би; тийм ээ, болгоогтун, бошиглогч Зинос зоригтойгоор гэрчилсэн билээ; үүнийхээ төлөө тэр алагдсан юм.
- 20 Мөн болгоогтун, түүнчлэн Зинок, мөн түүнчлэн Эсиас, мөн түүнчлэн Исаиа, мөн Иеремиа, (Иеремиа бол Иерусалимын устгалын тухай гэрчилсэн бошиглогч билээ) мөн эдүгээ бид Иеремиагийн үгсийн дагуу Иерусалим устгагдсаныг мэднэ. Ай тэгвэл түүний бошиглолын дагуу, Бурханы Хүү яагаад ирэхгүй гэж
- 21 Мөн эдүгээ та нар Иерусалим устгагдсан талаар маргах уу? Та нар Зедикаягийн хөвгүүд, Мюлекээс бусад нь бүгд алагдаагүй гэж хэлэх үү? Тийм ээ, мөн та нар Зедикаягийн үр удам бидэнтэй хамт буйг, мөн тэд Иерусалимын нутгаас гаргагдсаныг болгоох нь үгүй гэж үү? Гэвч болгоогтун, энэ нь бүгд бус—

And as many as should look upon that serpent should live, even so as many as should look upon the Son of God with faith, having a contrite spirit, might live, even unto that life which is eternal.

And now behold, Moses did not only testify of these things, but also all the holy prophets, from his days even to the days of Abraham.

Yea, and behold, Abraham saw of his coming, and was filled with gladness and did rejoice.

Yea, and behold I say unto you, that Abraham not only knew of these things, but there were many before the days of Abraham who were called by the order of God; yea, even after the order of his Son; and this that it should be shown unto the people, a great many thousand years before his coming, that even redemption should come unto them.

And now I would that ye should know, that even since the days of Abraham there have been many prophets that have testified these things; yea, behold, the prophet Zenos did testify boldly; for the which he was slain.

And behold, also Zenock, and also Ezias, and also Isaiah, and Jeremiah, (Jeremiah being that same prophet who testified of the destruction of Jerusalem) and now we know that Jerusalem was destroyed according to the words of Jeremiah. O then why not the Son of God come, according to his prophecy?

And now will you dispute that Jerusalem was destroyed? Will ye say that the sons of Zedekiah were not slain, all except it were Mulek? Yea, and do ye not behold that the seed of Zedekiah are with us, and they were driven out of the land of Jerusalem? But behold, this is not all—

- 22 Тэрбээр эдгээр зүйлийн талаар гэрчилсэн учир бидний өвөг Лихай Иерусалимаас гаргагдсан билээ. Нифай, мөн түүнчлэн бидний бараг бүх эцэг өвгөд, бүр энэ цагийг хүртэл түүнчлэн эдгээр зүйлийн талаар гэрчилсэн юм; тийм ээ, тэд Христийн ирэлтийн талаар гэрчилсэн, мөн хойшдыг харж, мөн ирэх түүний өдөрт баяссан билээ.
- 23 Мөн болгоогтун, тэр бол Бурхан мөн тэрээр тэдэнтэй хамт буй, мөн тэрээр өөрийгөө тэдэнд үзүүлсэн, тиймээс тэд түүгээр гэтэлгэгдсэн бөлгөө; мөн тэд ирэх зүйлийн учир түүнд алдар гавьяаг өгөх болно.
- 24 Мөн эдүгээ, та нар эдгээр зүйлийг мэддэг мөн та нар худал хэлэхээс бусдаар тэдгээрийг үгүйсгэж чадахгүйн учир, тиймийн тул үүнд та нар нүгэл үйлдсэн, учир нь та нар, ийм олон нотолгоо хүлээн авсан хэдий ч эдгээр бүх зүйлийг эсэргүүцсэн тэр; тийм ээ, та нар бүр бүх зүйлийг хүлээн авсан, тэнгэр дэх зүйлүүд, мөн газар дээрх бүх зүйлийг аль алиныг нь, нэгэн гэрчлэгчийн адилаар тэдгээр нь үнэн болохыг хүлээн авсан билээ.
- 25 Гэвч болгоогтун, та нар үнэнийг үгүйсгэж, мөн ариун Бурханыхаа эсрэг эсэргүүцсэн; мөн бүр энэ цагт, цэвэр бус юухан ч орж чадахгүй тэнд юу ч ялзардаггүй тэнгэрт өөрсдөдөө эрдэнэс хураахын оронд та нар шүүлтийн өдөрт өөрсдөдөө уур хилэнг овоолон бөөгнүүлэх юм.
- 26 Тийм ээ, бүр энэ цаг үед ч та нар аллагуудынхаа мөн завхайрлынхаа мөн ёс бусынхаа учир үүрдийн устгалд боловсорч байна; тийм ээ, мөн та нар наманчлахгүй аваас энэ нь та нарт удахгүй ирэх болно.
- 27 Тийм ээ, болгоогтун энэ нь эдүгээ үүдэн дээр чинь байна; тийм ээ, та нар шүүлтийн суудалд очиж, мөн үзэцгээ; мөн болгоогтун, шүүгч чинь алагдсан буй, мөн тэр цусандаа хутгалдан хэвтэж байгаа; мөн шүүлтийн суудалд суухыг эрэлхийлсэн дүүдээ тэрээр алагджээ.
- 28 Мөн болгоогтун, Гадантон мөн хүмүүний бодгалийг устгахыг эрэлхийлэх хилэнцэт нэгнээр үүсгэгдсэн та нарын нууц бүлэглэлд тэдний аль аль нь харьяалагддаг билээ.

Our father Lehi was driven out of Jerusalem because he testified of these things. Nephi also testified of these things, and also almost all of our fathers, even down to this time; yea, they have testified of the coming of Christ, and have looked forward, and have rejoiced in his day which is to come.

And behold, he is God, and he is with them, and he did manifest himself unto them, that they were redeemed by him; and they gave unto him glory, because of that which is to come.

And now, seeing ye know these things and cannot deny them except ye shall lie, therefore in this ye have sinned, for ye have rejected all these things, notwithstanding so many evidences which ye have received; yea, even ye have received all things, both things in heaven, and all things which are in the earth, as a witness that they are true.

But behold, ye have rejected the truth, and rebelled against your holy God; and even at this time, instead of laying up for yourselves treasures in heaven, where nothing doth corrupt, and where nothing can come which is unclean, ye are heaping up for yourselves wrath against the day of judgment.

Yea, even at this time ye are ripening, because of your murders and your fornication and wickedness, for everlasting destruction; yea, and except ye repent it will come unto you soon.

Yea, behold it is now even at your doors; yea, go ye in unto the judgment-seat, and search; and behold, your judge is murdered, and he lieth in his blood; and he hath been murdered by his brother, who seeketh to sit in the judgment-seat.

And behold, they both belong to your secret band, whose author is Gadianon and the evil one who seeketh to destroy the souls of men.

## Хиламан 9

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Нифай эдгээр үгсийг ярьсны дараа, тэдний дунд байсан хэдэн хүн шүүлтийн суудлын зүг гүйж одов; тийм ээ, бүр явсан нь тав байв, мөн тэд явах зуураа өөр хоорондоо хэлэлцэв:
- 2 Болгоогтун, эдүгээ энэ хүн бошиглогч мөн эсэхийг мөн Бурхан ийм гайхам зүйлүүдийг бидэнд бошиглохыг түүнд зарлигласан эсэхийг бид гарцаагүй мэдэх болно. Болгоогтун, тэр тэгсэн гэдэгт бид итгэхгүй байна; тийм ээ, бид түүнийг бошиглогч гэдэгт итгэхгүй байна; гэсэн хэдий ч, хэрэв ерөнхий шүүгчийн талаар түүний хэлсэн энэ зүйл үнэн байж, тэрээр үхсэн байвал, тэгвэл бид түүний ярьсан бусад үг нь ч үнэн гэдэгт итгэнэ.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэд чадлаараа гүйж мөн шүүлтийн суудалд ирэв; мөн болгоогтун, ерөнхий шүүгч газарт унаж, мөн цусандаа хутгалдан хэвтэж байв.
- 4 Мөн эдүгээ болгоогтун, тэд үүнийг хараад тэд үлэмж гайхан цочирдож, үүний хэрээр тэд газар унав; учир нь тэд ерөнхий шүүгчийн талаар Нифайн ярьсан үгсэд итгээгүй байжээ.
- 5 Гэвч эдүгээ, тэд хараад итгэж, мөн Нифайн ярьсан тэр бүх шүүлтүүд уг хүмүүсийн дээр ирэх болуузай хэмээх айдас тэдний дээр ирэв; тиймийн тул тэд салгалан, мөн газарт унасан ажээ.
- 6 Эдүгээ, шүүгч алагдсан тэр даруй—тэрээр дүрээ хувиргасан дүүдээ хутгалуулсан байж, мөн тэр нь зугтаж, мөн зарц нар нь гүйлдэж бас хүмүүст хэлэв, тэдний дунд аллагын зар түгэв;
- 7 Мөн болгоогтун хүмүүс шүүлтийн суудал буй тэр газарт нэгдэн цугларч—мөн болгоогтун, газарт унасан таван эрийг тэд гайхан харцгаав.
- 8 Мөн эдүгээ болгоогтун, уг хүмүүс Нифайн цэцэрлэгт цугларсан тэрхүү хүмүүсийн талаар юу ч мэдсэнгүй; тиймийн тул тэд өөр хоорондоо хэлэлцэв: Шүүгчийг алсан тэд бол эдгээр эрчүүд болой, мөн тэд биднээс зугтаж чадахгүйн тул Бурхан тэднийг цохьжээ хэмээцгээв.

## Helaman 9

Behold, now it came to pass that when Nephi had spoken these words, certain men who were among them ran to the judgment-seat; yea, even there were five who went, and they said among themselves, as they went:

Behold, now we will know of a surety whether this man be a prophet and God hath commanded him to prophesy such marvelous things unto us. Behold, we do not believe that he hath; yea, we do not believe that he is a prophet; nevertheless, if this thing which he has said concerning the chief judge be true, that he be dead, then will we believe that the other words which he has spoken are true.

And it came to pass that they ran in their might, and came in unto the judgment-seat; and behold, the chief judge had fallen to the earth, and did lie in his blood.

And now behold, when they saw this they were astonished exceedingly, insomuch that they fell to the earth; for they had not believed the words which Nephi had spoken concerning the chief judge.

But now, when they saw they believed, and fear came upon them lest all the judgments which Nephi had spoken should come upon the people; therefore they did quake, and had fallen to the earth.

Now, immediately when the judge had been murdered—he being stabbed by his brother by a garb of secrecy, and he fled, and the servants ran and told the people, raising the cry of murder among them;

And behold the people did gather themselves together unto the place of the judgment-seat—and behold, to their astonishment they saw those five men who had fallen to the earth.

And now behold, the people knew nothing concerning the multitude who had gathered together at the garden of Nephi; therefore they said among themselves: These men are they who have murdered the judge, and God has smitten them that they could not flee from us.



- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд тэднийг баривчилж мөн тэднийг хүлээд мөнхүү тэднийг шоронд хаялаа. Мөн шүүгч алагдсан хийгээд, мөн алуурчид нь баривчлагдаж, шоронд хаягдсан хэмээх тунхаг бичиг тараагдан илгээгдэв.
- 10 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь хүмүүс алагдсан агуу ерөнхий шүүгчийнхээ оршуулган дээр гашуудан мөн мацаг барихаар чуулан цуглацгаав.
- 11 Мөн түүнчлэн Нифайн цэцэрлэгт байж, мөн түүний үгсийг сонссон шүүгчид ч тийн, оршуулган дээр нэгдэн цугларсан байв.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэд хүмүүсийн дунд сураглаж, хэлрүүн: Ерөнхий шүүгч үхсэн эсэхийг сураглуулахаар илгээсэн таван хүн хаана байна? Мөн тэд хариулж мөн хэлэв: Та нарын илгээсэн гэх тэр тавын талаар бид мэдэхгүй; харин бидний шоронд хаясан, алуурчид болох тэр тав бий.
- 13 Мөнхүү улиран тохиох дор шүүгчид тэднийг авчрахыг хүсэв; мөн тэд авчрагдаж, мөн болгоогтун илгээгдсэн тав нь тэд байв; мөн болгоогтун шүүгчид тэднээс уг хэргийн талаар мэдэхээр асууж, мөн тэд өөрсдийн үйлдсэн бүгдийг тэдэнд өгүүлж, хэлсэн нь:
- 14 Бид гүйлдэж мөн шүүлтийн суудал буй тэр газар ирсэн, мөн бүх зүйл бүр Нифайн гэрчилсний дагуу байхыг бид үзэж, бид гайхшираад, үүний хэрээр бид газарт унасан; мөн биднийг ухаан ороход, болгоогтун тэд биднийг шоронд хаясан бөлгөө.
- 15 Эдүгээ, энэ хүн алагдсан талаар, хэн үүнийг үйлдсэнийг бид мэдэхгүй; мөн зөвхөн энэ зэргийг л бид мэднэ, бид та нарын хүссэний дагуу гүйж мөн ирсэн, мөн болгоогтун Нифайн үгсийн дагуу, тэр үхчихсэн байсан.
- 16 Мөн эдүгээ улиран тохиох дор шүүгчид уг хэргийг хүмүүст тайлбарлаж, мөн Нифайн эсрэг хашгиралдан, өгүүлсэн нь: Болгоогтун, тэрээр биднийг өөрийн сүсэг бишрэлд урвуулж болохын тулд, тэрээр агуу хүн, Бурханаар сонгогдсон мөн бошиглогч хэмээн өөрийгөө өргөмжилж болохын тулд, дараа нь тэрээр үүнийг бидэнд тунхаглаж болохын тулд энэ нифай шүүгчийг алахаар хэн нэгэнтэй тохиролцсон байх ёстойг бид мэднэ.

And it came to pass that they laid hold on them, and bound them and cast them into prison. And there was a proclamation sent abroad that the judge was slain, and that the murderers had been taken and were cast into prison.

And it came to pass that on the morrow the people did assemble themselves together to mourn and to fast, at the burial of the great chief judge who had been slain.

And thus also those judges who were at the garden of Nephi, and heard his words, were also gathered together at the burial.

And it came to pass that they inquired among the people, saying: Where are the five who were sent to inquire concerning the chief judge whether he was dead? And they answered and said: Concerning this five whom ye say ye have sent, we know not; but there are five who are the murderers, whom we have cast into prison.

And it came to pass that the judges desired that they should be brought; and they were brought, and behold they were the five who were sent; and behold the judges inquired of them to know concerning the matter, and they told them all that they had done, saying:

We ran and came to the place of the judgment-seat, and when we saw all things even as Nephi had testified, we were astonished insomuch that we fell to the earth; and when we were recovered from our astonishment, behold they cast us into prison.

Now, as for the murder of this man, we know not who has done it; and only this much we know, we ran and came according as ye desired, and behold he was dead, according to the words of Nephi.

And now it came to pass that the judges did expound the matter unto the people, and did cry out against Nephi, saying: Behold, we know that this Nephi must have agreed with some one to slay the judge, and then he might declare it unto us, that he might convert us unto his faith, that he might raise himself to be a great man, chosen of God, and a prophet.

- 17 Мөн эдүгээ болгоогтун, бид энэ хүнийг илчлэх болно, мөн тэрээр буруугаа хүлээж мөн энэ шүүгчийн алуурчин чухам хэн болохыг бидэнд мэдүүлэх болно.
- 18 Мөнхүү улиран тохиох дор сайхь тав оршуулгын өдөр суллагдав. Гэсэн хэдий ч, Нифайн эсрэг ярьсан түүний үгсийн талаар тэд шүүгчдийг буруутгаж, мөн тэдэнтэй нэг нэгээрээ зөрөлдөв, үүний хэрээр тэд тэднийг хэлэх үггүй болгов.
- 19 Гэсэн хэдий ч, тэд Нифайг баривчлагдаж мөн хүлэгдэж мөн цугласан олны өмнө авчрагдахаар болгож, мөн тэд түүнийг үхэлд хүргэхээр буруутгаж болохын тулд, үгсийг нь авцалдахгүй болгохоор янз янзын аргаар түүнийг шалгааж эхлэв—
- 20 Түүнд хэлэв: Чи бол хамсаатан нь; энэ аллагыг үйлдсэн хүн хэн бэ? Эдүгээ бидэнд хэлэгтүн, мөн буруугаа хүлээн зөвшөөр; хэлрүүн, Болгоогтун мөнгө энэ байна; мөн хэрэв чи бидэнд хэлэх юм бол, мөн түүнтэй хийсэн гэрээ байгаагаа хүлээвэл бид амийг чинь түүнчлэн хэлтрүүлэх болно.
- 21 Гэвч Нифай тэдэнд хэлэв: Ай мунхаг та нар, зүрх сэтгэл нь хөндөгдөөгүй та нар, харалган та нар, мөн зөрүүд хүмүүс та нар, энэхүү нүглийн замаараа явсаар байхыг чинь Их Эзэн Бурхан тань хэр удаан хүлцэхийг та нар мэдэх үү
- 22 Ай та нар наманчлахгүй аваас, энэ үед та нарыг хүлээх агуу устгалын учир орь дуу тавин мөн гашуудаж эхэлбэл зохино, та нар.
- 23 Болгоогтун манай ерөнхий шүүгч Сизромыг алуулахаар хэн нэгэн хүнтэй намайг зөвшилцсөн хэмээн та нар хэлж байна. Гэвч болгоогтун, би та нарт хэлнэ, энэ зүйлийг та нар мэдэж болохын тулд би та нарт гэрчилсний улмаас энэ болой, тийм ээ, бүр би та нарын дундах ёс бус үйлүүд хийгээд жигшүүрт хэргүүдийг мэдсэнийг та нарт гэрчлэх гэрчлэлийн тулд билээ.
- 24 Мөн би үүнийг үйлдсэн учир, энэ зүйлийг үйлдүүлэхээр хэн нэгэнтэй намайг зөвшилцсөн хэмээн та нар хэлж байна; тийм ээ, би та нарт энэ тэмдгийг үзүүлсэн учир та нар надад уурлаж, амийг минь егүүтгэхийг эрэлхийлж байна.

And now behold, we will detect this man, and he shall confess his fault and make known unto us the true murderer of this judge.

And it came to pass that the five were liberated on the day of the burial. Nevertheless, they did rebuke the judges in the words which they had spoken against Nephi, and did contend with them one by one, inso-much that they did confound them.

Nevertheless, they caused that Nephi should be taken and bound and brought before the multitude, and they began to question him in divers ways that they might cross him, that they might accuse him to death—

Saying unto him: Thou art confederate; who is this man that hath done this murder? Now tell us, and acknowledge thy fault; saying, Behold here is money; and also we will grant unto thee thy life if thou wilt tell us, and acknowledge the agreement which thou hast made with him.

But Nephi said unto them: O ye fools, ye uncircumcised of heart, ye blind, and ye stiffnecked people, do ye know how long the Lord your God will suffer you that ye shall go on in this your way of sin?

O ye ought to begin to howl and mourn, because of the great destruction which at this time doth await you, except ye shall repent.

Behold ye say that I have agreed with a man that he should murder Seezoram, our chief judge. But behold, I say unto you, that this is because I have testified unto you that ye might know concerning this thing; yea, even for a witness unto you, that I did know of the wickedness and abominations which are among you.

And because I have done this, ye say that I have agreed with a man that he should do this thing; yea, because I showed unto you this sign ye are angry with me, and seek to destroy my life.

25 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт өөр нэгэн тэмдэг үзүүлэх болно, мөн та нар энэ зүйлийн учир намайг устгахыг эрэлхийлэх эсэхийг үзье.

26 Болгоогтун би та нарт хэлнэ: Сизромын дүү нь болох, Сийнтумын гэрт очиж, мөн түүнд хэл—

27 Бошиглогчийн дүр үзүүлэгч, нифай энэ хүмүүсийн талаар их хилэнцгийг бошиглох тэрбээр, ах чинь болох Сизромыг алахад чинь, тантай зөвшилцсөн үү

28 Мөн болгоогтун, тэрээр та нарт, Үгүй гэж хэлэх болно.

29 Мөн та нар түүнд хэлэх болно: Та ахыгаа алсан уу

30 Мөн тэрээр айн зогсож, мөн юу хэлэхээ мэдэхгүй байх болно. Мөн болгоогтун, тэрээр та нарт үгүйсгэж болно; мөн тэрээр гайхширч балмагдсан лугаа адил үйлдэх болно; гэсэн хэдий ч, тэрээр гэмгүй гэдгээ та нарт тунхаглах болно.

31 Гэвч болгоогтун, та нар түүнийг шалгах болно, мөн та нар түүний нөмрөгийн хормой дээрх цусыг олох болно.

32 Мөн та нар үүнийг хараад, та нар хэлнэ: Хаанаас энэ цус болов? Энэ бол танай ахын цус гэдгийг бид мэдэхгүй гэж үү

33 Мөн тэгэхэд тэрээр салгалж, мөн бүр түүний дээр үхэл ирсэн мэтээр тэр цонхигор харагдах болно.

34 Мөн тэгэхэд та нар хэлнэ: Энэ айдсыг мөн царайд чинь тодрох тэр цонхигор байдлын учир, болгоогтун, гэмтэйг тань бид мэдэв.

35 Мөн тэгэхэд илүү их айдас түүний дээр ирэх болно; мөн тэгээд тэрээр хүлээж, мөн энэхүү аллагыг хийснээ цаашид үгүйсгэхгүй болой.

36 Мөн тэгээд тэрээр та нарт, Бурханы хүчээр надад өгөгдөхөөс бусдаар бол уг хэргийн талаар Нифай намайг юу ч мэдэхгүй хэмээн хэлэх болно. Мөн тэгэхэд та нар намайг шударга хүн, мөн би бол Бурханаас та нарт илгээгдсэнийг мэдэх болно.

37 Мөнхүү улиран тохиох дор тэд одож, мөн, бүр Нифайн тэдэнд хэлсний дагуу үйлдэв. Мөн болгоогтун, түүний хэлсэн үгс үнэн байв; учир нь тэрхүү үгсийн дагуу тэрээр үгүйсгэж; мөн түүнчлэн тэрхүү үгсийн дагуу тэрээр хүлээв.

And now behold, I will show unto you another sign, and see if ye will in this thing seek to destroy me.

Behold I say unto you: Go to the house of Seantum, who is the brother of Seezoram, and say unto him—

Has Nephi, the pretended prophet, who doth prophesy so much evil concerning this people, agreed with thee, in the which ye have murdered Seezoram, who is your brother?

And behold, he shall say unto you, Nay.

And ye shall say unto him: Have ye murdered your brother?

And he shall stand with fear, and wist not what to say. And behold, he shall deny unto you; and he shall make as if he were astonished; nevertheless, he shall declare unto you that he is innocent.

But behold, ye shall examine him, and ye shall find blood upon the skirts of his cloak.

And when ye have seen this, ye shall say: From whence cometh this blood? Do we not know that it is the blood of your brother?

And then shall he tremble, and shall look pale, even as if death had come upon him.

And then shall ye say: Because of this fear and this paleness which has come upon your face, behold, we know that thou art guilty.

And then shall greater fear come upon him; and then shall he confess unto you, and deny no more that he has done this murder.

And then shall he say unto you, that I, Nephi, know nothing concerning the matter save it were given unto me by the power of God. And then shall ye know that I am an honest man, and that I am sent unto you from God.

And it came to pass that they went and did, even according as Nephi had said unto them. And behold, the words which he had said were true; for according to the words he did deny; and also according to the words he did confess.

38 Мөн тэрээр өөрөө тэрхүү алуурчин гэдгээ нотлохоор авчрагдсан байв, үүний хэрээр мөнөөх тав мөн түүнчлэн Нифай чөлөөлөгдөв.

39 Мөн нифайчуудаас Нифайн үгсэд итгэсэн зарим нь байв; мөн тэрхүү тавын гэрчлэлийн улмаас түүнчлэн итгэсэн зарим нь байв, учир нь тэд шоронд байхдаа хөрвүүлэгдсэн байв.

40 Мөн эдүгээ хүмүүсийн дунд Нифай бол бошиглогч хэмээн хэлдэг зарим нь байв.

41 Мөн ийн хэлэх бусад зарим нь байв: Болгоогтун, тэр бол нэгэн Бурхан, учир нь тэр нэгэн Бурхан бус аваас бүх зүйлийг мэдэж чадахгүй байсан билээ. Учир нь болгоогтун, тэрээр зүрх сэтгэлийн маань бодлуудыг хэлсэн, мөн түүнчлэн юмсыг хэлсэн бидэнд билээ; мөн тэрээр бүр ерөнхий шүүгчийг маань алсан жинхэнэ алуурчныг бидний мэдлэгт авчирсан бөлгөө.

And he was brought to prove that he himself was the very murderer, insomuch that the five were set at liberty, and also was Nephi.

And there were some of the Nephites who believed on the words of Nephi; and there were some also, who believed because of the testimony of the five, for they had been converted while they were in prison.

And now there were some among the people, who said that Nephi was a prophet.

And there were others who said: Behold, he is a god, for except he was a god he could not know of all things. For behold, he has told us the thoughts of our hearts, and also has told us things; and even he has brought unto our knowledge the true murderer of our chief judge.

## Хиламан 10

- 1 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн дунд хагарал үүсч, үүний хэрээр тэд нааш цааш хуваагдаж мөн тэдний дунд зогсож байхад нь Нифайг ганцааранг нь орхин, тэд замаараа одоцгоов.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн өөрт нь үзүүлсэн зүйлүүдийн талаар эргэцүүлсээр Нифай гэр рүүгээ чиглэн замаараа одов.
- 3 Мөнхүү улиран тохиох дор түүнийг ийн эргэцүүлэх зуур—тэрээр Нифайн хүмүүсийн ёс бус үйлүүд, тэдний харанхуйн нууц ажлууд, мөн тэдний аллагууд мөн тэдний тонуулууд, мөн бүх төрлийн алдсуудынх нь учир ихэд гутарч байв—мөн улиран тохиох дор түүнийг зүрх сэтгэлдээ ийн эргэцүүлж байх зуур, болгоогтун, нэгэн дуу хоолой түүнд ирж хэлрүүн:
- 4 Адислагдсан болой чи, Нифай, чиний хийсэн зүйлүүдийн учир; учир нь чамд миний өгсөн үгийг энэ хүмүүст ядрахаа мэдэхгүй яаж тунхагласныг чинь би болгоосон. Мөн чи тэднээс айсангүй, мөн амьдралаа эрэлхийлсэнгүй, харин миний тааллыг, мөн зарлигуудыг минь дагахыг эрэлхийллээ.
- 5 Мөн эдүгээ, чи үүнийг ингэж ядрахаа мартан хийсэн учир, болгоогтун, би чамайг үүрд адислах болно; мөн би чамайг үгэнд мөн үйлэнд, итгэлд мөн ажилд ч хүчирхэг болгох болно; тийм ээ, бүр бүх зүйл чиний үгийн дагуу чамд хийгдэх болно, учир нь тааллын минь эсрэг зүйлийг чи эс гуйдаг билээ.
- 6 Болгоогтун, чи бол Нифай, мөн бибээр Бурхан. Болгоогтун, чи энэ хүмүүсийн дээр хүчтэй байна, мөн энэ хүмүүсийн ёс бус үйлүүдийн дагуу газрыг өлсгөлөнгөөр, мөн тахлаар, мөн устгалаар цохих болно хэмээн тэнгэр элчүүдийнхээ дэргэд би үүнийг чамд тунхаглаж байна.
- 7 Болгоогтун, Би чамд хүчийг өгье, иймээс газарт лацадсан болгон чинь тэнгэрт лацдагдах болно; мөн газарт цуцалсан бүхэн чинь тэнгэрт цуцлагдах болно; мөн энэ хүмүүсийн дунд чамд тийм хүч байх болно.
- 8 Мөн тийн, хэрэв чи энэ ариун сүмд хоёр хуваагдан цуур гэж хэлэх аваас энэ нь хийгдэх болно.
- 9 Мөн хэрэв чи энэ ууланд, чи нурж мөн тал бол гэж хэлбэл, энэ нь хийгдэх болно.

## Helaman 10

And it came to pass that there arose a division among the people, insomuch that they divided hither and thither and went their ways, leaving Nephi alone, as he was standing in the midst of them.

And it came to pass that Nephi went his way towards his own house, pondering upon the things which the Lord had shown unto him.

And it came to pass as he was thus pondering—being much cast down because of the wickedness of the people of the Nephites, their secret works of darkness, and their murderings, and their plunderings, and all manner of iniquities—and it came to pass as he was thus pondering in his heart, behold, a voice came unto him saying:

Blessed art thou, Nephi, for those things which thou hast done; for I have beheld how thou hast with unwearyingness declared the word, which I have given unto thee, unto this people. And thou hast not feared them, and hast not sought thine own life, but hast sought my will, and to keep my commandments.

And now, because thou hast done this with such unwearyingness, behold, I will bless thee forever; and I will make thee mighty in word and in deed, in faith and in works; yea, even that all things shall be done unto thee according to thy word, for thou shalt not ask that which is contrary to my will.

Behold, thou art Nephi, and I am God. Behold, I declare it unto thee in the presence of mine angels, that ye shall have power over this people, and shall smite the earth with famine, and with pestilence, and destruction, according to the wickedness of this people.

Behold, I give unto you power, that whatsoever ye shall seal on earth shall be sealed in heaven; and whatsoever ye shall loose on earth shall be loosed in heaven; and thus shall ye have power among this people.

And thus, if ye shall say unto this temple it shall be rent in twain, it shall be done.

And if ye shall say unto this mountain, Be thou cast down and become smooth, it shall be done.

- 10 Мөн болгоогтун, хэрэв Бурхан энэ хүмүүсийг цохих болно гэж чи хэлэх аваас, энэ нь улиран тохиох болно.
- 11 Мөн эдүгээ болгоогтун, чи явж, та нар наманчлахгүй аваас, бүр устгалд хүргэн цохигдох болно гэж Бүхнийг чадагч Их Эзэн Бурхан ийн хэлж байна хэмээн мөн энэ хүмүүст тунхаглахыг би чамд зарлиг болгож байна буюу.
- 12 Мөн болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Их Эзэн эдгээр үгсийг Нифайд ярьсны дараа, тэрээр зогсож мөн гэртээ одсонгүй, харин нутгийн гадаргуу дээр тархсан хүмүүсийн зүг эргэж очоод, мөн хэрэв тэд наманчлахгүй аваас тэдний устгалын талаарх түүнд яригдсан Их Эзэний үгийг тэдэнд тунхаглаж эхлэв.
- 13 Эдүгээ болгоогтун, Нифай тэдэнд ерөнхий шүүгчийн үхлийн талаар хэлсэн нь агуу гайхамшиг байсан хэдий ч, тэд зүрх сэтгэлээ хатууруулж мөн Их Эзэний үгсийг анхааран сонссонгүй.
- 14 Тиймийн тул Нифай тэдэнд Их Эзэний үгийг тунхаглаж, өгүүлсэн нь: Та нар наманчлахгүй аваас, та нар бүр устгалд хүргэн цохигдох болно хэмээн Их Эзэн хэлэв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү үгийг Нифай тэдэнд тунхаглахад, болгоогтун, тэд зүрх сэтгэлээ хатууруулсан хэвээр байж мөн түүний үгсийг анхааран сонсохгүй байв; тиймийн тул тэд түүний эсрэг доромжлон, мөн түүнийг шоронд хаяж болохын тулд түүнд гар хүрэхийг завдав.
- 16 Гэвч болгоогтун, Бурханы хүч түүн дээр оршиж, мөн тэд түүнийг шоронд хаяхаар баривчилж чадсангүй, учир нь тэрээр Сүнсээр авагдаж мөн тэдний дундаас зөөгдөн одов.
- 17 Мөнхүү улиран тохиох дор тэрээр тийн Сүнсний нөлөөн дор, цугласан олноос цугласан олонд очиж, Бурханы үгийг, бүр тэдэнд бүгдэд нь тунхаглаж, өөрөөр хэлбэл бүх хүмүүсийн дунд илгээх хүртлээ тунхагласан билээ.
- 18 Мөнхүү улиран тохиох дор тэд түүний үгсийг анхааран сонсохгүй байв; мөн зөрчилдөөнүүд эхэлж, үүний хэрээр тэд өөр хоорондоо хуваагдаж мөн нэг нэгнээ илдээр хөнөөж эхлэв.

And behold, if ye shall say that God shall smite this people, it shall come to pass.

And now behold, I command you, that ye shall go and declare unto this people, that thus saith the Lord God, who is the Almighty: Except ye repent ye shall be smitten, even unto destruction.

And behold, now it came to pass that when the Lord had spoken these words unto Nephi, he did stop and did not go unto his own house, but did return unto the multitudes who were scattered about upon the face of the land, and began to declare unto them the word of the Lord which had been spoken unto him, concerning their destruction if they did not repent.

Now behold, notwithstanding that great miracle which Nephi had done in telling them concerning the death of the chief judge, they did harden their hearts and did not hearken unto the words of the Lord.

Therefore Nephi did declare unto them the word of the Lord, saying: Except ye repent, thus saith the Lord, ye shall be smitten even unto destruction.

And it came to pass that when Nephi had declared unto them the word, behold, they did still harden their hearts and would not hearken unto his words; therefore they did revile against him, and did seek to lay their hands upon him that they might cast him into prison.

But behold, the power of God was with him, and they could not take him to cast him into prison, for he was taken by the Spirit and conveyed away out of the midst of them.

And it came to pass that thus he did go forth in the Spirit, from multitude to multitude, declaring the word of God, even until he had declared it unto them all, or sent it forth among all the people.

And it came to pass that they would not hearken unto his words; and there began to be contentions, in-somuch that they were divided against themselves and began to slay one another with the sword.

19 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын далан нэгдүгээр он ийн төгсөв.

And thus ended the seventy and first year of the reign of the judges over the people of Nephi.

## Хиламан 11

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор шүүгчдийн засаглалын далан хоёр дахь онд зөрчилдөөнүүд нэмэгдэж, үүний хэрээр Нифайн бүх хүмүүсийн дунд бүх нутаг даяар дайнууд байв.
- 2 Мөн устгалын мөн ёс бус үйлүүдийн энэ ажлыг өдөөгчид нь дээрэмчдийн энэхүү нууц бүлэглэл байв. Мөн энэ дайн бүтэн жил үргэлжилж; мөн далан гуравдугаар онд ч энэ нь түүнчлэн үргэлжлэв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор энэ онд Нифай Их Эзэнээс гуйн залбирч, хэлсэн нь:
- 4 Ай Их Эзэн, энэ хүмүүсийг илдээр устгагдахыг бүү хүлцээч; харин Ай Их Эзэн, түүний оронд тэд наманчилж мөн танд хандаж магадын тул Их Эзэн Бурханаа санахад тэднийг өдөөн хатгаж, энэ нутагт өлсгөлөнг байлгаач.
- 5 Мөн үүнчлэн энэ нь Нифайн үгсийн дагуу хийгдэв. Мөн уг нутгийн дээр, Нифайн бүх хүмүүсийн дунд их өлсгөлөн болов. Мөн далан дөрөвдүгээр онд тийн өлсгөлөн үргэлжилж, мөн устгалын ажил нь илдээр байхаа больж харин өлсгөлөнгөөр улам гаарав.
- 6 Мөн энэхүү устгалын ажил түүнчлэн далан тавдугаар онд ч үргэлжлэв. Газар цохигдсон учир хуурай байж, мөн үр тарианы улиралд үр тариа гарсангүй; мөн бүхэл газар дэлхий цохигдож, бүр нифайчуудын дундахтай нэгэн адил леменчүүдийн дунд, үүнчлэн уг нутгийн илүү ёс бус хэсэгт нь тэд мянга мянгаараа мөхөхөөр, тэд цохигдов.
- 7 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс тэд өлсгөлөнгөөр мөхөх гэж буйгаа хараад, мөн тэд Их Эзэн Бурханаа санаж эхлэв; мөн тэд Нифайн үгсийг санаж эхлэв.
- 8 Мөн уг хүмүүс ерөнхий шүүгчдээсээ мөн удирдагчдаасаа, тэд Нифайд ийн хэлэхийг гуйж эхлэв: Болгоогтун, бид таныг Бурханы хүн гэдгийг мэднэ, мөн тиймийн тул бидний устгалын талаар таны ярьсан бүх үгс биелэгдэхгүйн тулд тэр энэ өлсгөлөнг биднээс зайлуулаач хэмээн Их Эзэн бидний Бурханаас гуйгаач.

## Helaman 11

And now it came to pass in the seventy and second year of the reign of the judges that the contentions did increase, insomuch that there were wars throughout all the land among all the people of Nephi.

And it was this secret band of robbers who did carry on this work of destruction and wickedness. And this war did last all that year; and in the seventy and third year it did also last.

And it came to pass that in this year Nephi did cry unto the Lord, saying:

O Lord, do not suffer that this people shall be destroyed by the sword; but O Lord, rather let there be a famine in the land, to stir them up in remembrance of the Lord their God, and perhaps they will repent and turn unto thee.

And so it was done, according to the words of Nephi. And there was a great famine upon the land, among all the people of Nephi. And thus in the seventy and fourth year the famine did continue, and the work of destruction did cease by the sword but became sore by famine.

And this work of destruction did also continue in the seventy and fifth year. For the earth was smitten that it was dry, and did not yield forth grain in the season of grain; and the whole earth was smitten, even among the Lamanites as well as among the Nephites, so that they were smitten that they did perish by thousands in the more wicked parts of the land.

And it came to pass that the people saw that they were about to perish by famine, and they began to remember the Lord their God; and they began to remember the words of Nephi.

And the people began to plead with their chief judges and their leaders, that they would say unto Nephi: Behold, we know that thou art a man of God, and therefore cry unto the Lord our God that he turn away from us this famine, lest all the words which thou hast spoken concerning our destruction be fulfilled.



- 9 Мөнхүү улиран тохиох дор шүүгчид хүсэгдсэн энэхүү үгсийн дагуу, Нифайд хэлэв. Мөнхүү улиран тохиох дор хүмүүс наманчилж мөн таар өмсөн өөрсдийгөө даруу болгосныг Нифай үзээд, тэрээр Их Эзэнд дахин залбиран гуйж, хэлрүүн:
- 10 Ай Их Эзэн, болгоогтун энэ хүмүүс наманчлав; мөн тэд дундаасаа Гадантоны бүлэглэлийг шүүрдэн зайлуулж, үүний хэрээр тэд үгүй болж, мөн тэдний нууц төлөвлөгөөнүүдийг газарт далдлан нуужээ.
- 11 Эдүгээ, Ай Их Эзэн, тэдний энэхүү даруу байдлын учир та уур хилэнгээ буцаана уу, мөн таны аль хэдийн устгасан ёс бус хүмүүний устгалд таны хилэн тайтгараг.
- 12 Ай Их Эзэн, та уур хилэнгээ, тийм ээ, догшин ширүүн хилэнгээ буцаан мөн энэ нутагт өлсгөлөн зогсож болохын тулд үйлдэнэ үү.
- 13 Ай Их Эзэн, та намайг сонсож, мөн энэ нь миний үгсийн дагуу хийгдэхээр болгож, мөн тэр нь үр жимсээ мөн үр тарианы улиралд үр тариагаа өгч болохын тулд газрын гадаргуу дээр хур бороо илгээнэ үү.
- 14 Ай Их Эзэн, намайг, илдээр таригдах тахал зогсож болохын тулд, өлсгөлөн байг гэж хэлэхэд та үгсийг минь сонссон билээ; мөн: Хэрэв энэ хүмүүс наманчилбал би тэднийг хэлтрүүлэх болно хэмээн та хэлсэн учир, бүр энэ үед ч та үгсийг минь сонсох болно гэдгийг би мэднэ.
- 15 Тийм ээ, Ай Их Эзэн, мөн тэдний дээр ирсэн тэрхүү өлсгөлөн хийгээд тахал мөн устгалын учир тэд наманчилсныг та харж байна.
- 16 Мөн эдүгээ, Ай Их Эзэн, та уур хилэнгээ зайлуулан буцааж, мөн тэд танд үйлчлэх эсэхийг нь дахин сорино уу? Мөн хэрэв тийн байваас, Ай Их Эзэн, та хэлсэн үгсийнхээ дагуу тэднийг адисалж чадах билээ.
- 17 Мөнхүү улиран тохиох дор далан зургадугаар онд Их Эзэн уур хилэнгээ хүмүүсээс буцааж, мөн газарт бороо оруулахаар болгож, үүний хэрээр энэ нь үр жимсний улиралдаа үр жимсээ өгөв. Мөнхүү улиран тохиох дор үр тарианыхаа улиралд үр тариагаа өгөв.

And it came to pass that the judges did say unto Nephi, according to the words which had been desired. And it came to pass that when Nephi saw that the people had repented and did humble themselves in sackcloth, he cried again unto the Lord, saying:

O Lord, behold this people repenteth; and they have swept away the band of Gadianton from amongst them insomuch that they have become extinct, and they have concealed their secret plans in the earth.

Now, O Lord, because of this their humility wilt thou turn away thine anger, and let thine anger be appeased in the destruction of those wicked men whom thou hast already destroyed.

O Lord, wilt thou turn away thine anger, yea, thy fierce anger, and cause that this famine may cease in this land.

O Lord, wilt thou hearken unto me, and cause that it may be done according to my words, and send forth rain upon the face of the earth, that she may bring forth her fruit, and her grain in the season of grain.

O Lord, thou didst hearken unto my words when I said, Let there be a famine, that the pestilence of the sword might cease; and I know that thou wilt, even at this time, hearken unto my words, for thou saidst that: If this people repent I will spare them.

Yea, O Lord, and thou seest that they have repented, because of the famine and the pestilence and destruction which has come unto them.

And now, O Lord, wilt thou turn away thine anger, and try again if they will serve thee? And if so, O Lord, thou canst bless them according to thy words which thou hast said.

And it came to pass that in the seventy and sixth year the Lord did turn away his anger from the people, and caused that rain should fall upon the earth, insomuch that it did bring forth her fruit in the season of her fruit. And it came to pass that it did bring forth her grain in the season of her grain.

- 18 Мөн болгоогтун, уг хүмүүс баярлаж мөн Бурханыг алдаршуулав, мөн бүх газрын гадаргуу баяр баяслаар дүүргэгдэв; мөн тэд Нифайг устгахыг цаашид эрэлхийлсэнгүй, харин тэд түүнийг агуу бошиглогч, мөн Бурханаас агуу хүч хийгээд эрх мэдэл өгөгдсөн Бурханы хүний хувьд хүндлэн хүндлэх болов.
- 19 Мөн болгоогтун, түүний дүү, Лихай зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд түүний ард жаахан ч хоцорсонгүй.
- 20 Мөн ийн улиран тохиох дор Нифайн хүмүүс уг нутагт дахин дэгжиж эхлэв, мөн орхигдсон газруудаа дахин сэргээн босгож эхлэв, мөн бүр тэд уг нутгийн бүх гадаргууг бүрхэх хүртлээ, бас умардад мөн өмнөдөд ч, өрнөд тэнгисээс дорнод тэнгисийг хүртэл өнөржин мөн тархаж эхлэв.
- 21 Мөнхүү улиран тохиох дор далан зургадугаар он амар амгаланд төгсгөв. Мөн далан долдугаар он амар амгаланд эхлэв; мөн бүх нутгийн гадаргуу дээгүүр сүм тархав; мөн хүмүүсийн ихэнх хэсэг нь нифайчууд хийгээд леменчүүдийн аль аль нь сүмд харьяалагдсан байлаа; мөн уг нутагт үлэмж агуу амар амгалан тэдэнд байв; мөн далан долдугаар он тийн төгсөв.
- 22 Мөн бошиглогчдоор байгуулагдсан сургаалын заалтуудын талаар цөөн хэдэн зөрчилдөөнүүд байсныг эс тооцвол, далан наймдугаар онд түүнчлэн амар амгалан тэдэнд байв.
- 23 Мөн далан есдүгээр онд их маргаан байж эхлэв. Гэвч улиран тохиох дор Нифай, Лихай хоёр сургаалын үнэн заалтуудын талаар мэдсэн тэдний ах дүүсийн олон нь, өдөр бүр олон илчлэлт хүлээн авсан учир, тиймийн тул тэд хүмүүст номлож, үүний хэрээр тэд мөнхүү онд тэдний маргааныг төгсгөл болгов.
- 24 Мөнхүү улиран тохиох дор Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын наядугаар онд, хэдэн жилийн өмнө леменчүүдэд очиж, мөн өөрсдийн дээр леменчүүдийн нэрийг авсан Нифайн хүмүүсээс тэрслэгчдийн тодорхой тооны хэд нь, мөн түүнчлэн леменчүүдийн жинхэнэ үр удам асан тодорхой тооны хэд нь, тэднээр өөрөөр хэлбэл тэдгээр тэрслэгчдээр уурлуулахаар өдөөн хатгагдсан учир, тиймийн тул тэд ах дүүстэйгээ дайн эхлэв.

And behold, the people did rejoice and glorify God, and the whole face of the land was filled with rejoicing; and they did no more seek to destroy Nephi, but they did esteem him as a great prophet, and a man of God, having great power and authority given unto him from God.

And behold, Lehi, his brother, was not a whit behind him as to things pertaining to righteousness.

And thus it did come to pass that the people of Nephi began to prosper again in the land, and began to build up their waste places, and began to multiply and spread, even until they did cover the whole face of the land, both on the northward and on the southward, from the sea west to the sea east.

And it came to pass that the seventy and sixth year did end in peace. And the seventy and seventh year began in peace; and the church did spread throughout the face of all the land; and the more part of the people, both the Nephites and the Lamanites, did belong to the church; and they did have exceedingly great peace in the land; and thus ended the seventy and seventh year.

And also they had peace in the seventy and eighth year, save it were a few contentions concerning the points of doctrine which had been laid down by the prophets.

And in the seventy and ninth year there began to be much strife. But it came to pass that Nephi and Lehi, and many of their brethren who knew concerning the true points of doctrine, having many revelations daily, therefore they did preach unto the people, insomuch that they did put an end to their strife in that same year.

And it came to pass that in the eightieth year of the reign of the judges over the people of Nephi, there were a certain number of the dissenters from the people of Nephi, who had some years before gone over unto the Lamanites, and taken upon themselves the name of Lamanites, and also a certain number who were real descendants of the Lamanites, being stirred up to anger by them, or by those dissenters, therefore they commenced a war with their brethren.

25 Мөн тэд аллага хийгээд тонуул үйлдэж; мөн тэгээд тэд ууланд, мөн аглаг буйдад мөн нууц газруудаа буцаж ухраад, тэд илчлэгдэж болохооргүйгээр өөрсдийгөө нууж байв, мөн тэдэнд очих тэрслэгсэд байсны хэрээр тэд өдөр бүр тооны хувьд нэмэгдэж байв.

26 Мөн тийн хэсэг хугацаанд, тийм ээ, бүр олон бус жилийн дотор, тэд дээрэмчдийн үлэмж агуу бүлэглэл болов; мөн тэд Гадантоны бүх нууц төлөвлөгөөнүүдийг хайн олсон аж; мөн тэд тийн Гадантоны дээрэмчид болов.

27 Эдүгээ болгоогтун, эдгээр дээрэмчид агуу устгал, тийм ээ, бүр нифайчуудын ардын дунд, мөн түүнчлэн леменчүүдийн ардын дунд агуу устгалыг тарив.

28 Мөнхүү улиран тохиох дор энэ устгалын ажил зогсоогдох нь зайлшгүй байв; тиймийн тул тэд аглаг буйдад мөн уулсын дээр, дээрэмчдийн энэ бүлэглэлийг хайж олоод, мөн тэднийг устгахаар хүчирхэг эрсийн их цэргийг илгээв.

29 Гэвч болгоогтун, улиран тохиох дор мөнхүү онд тэд бүр өөрийн нутаг тийш туугдан ухраагдав. Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын наядугаар он тийн төгсөв.

30 Мөнхүү улиран тохиох дорнаян нэгдүгээр оны эхэнд тэд дахин дээрэмчдийн энэ бүлэглэлийн эсрэг явж, мөн олныг нь устгав; мөн тэд түүнчлэн их устгалаар зочлогдов.

31 Мөн ууланд болон аглаг буйдад бужигнах дээрэмчдийн үлэмж агуу тооны учир, тэд аглаг буйдаас болон уулнаас нутагтаа буцаж очихоор дахин албадуулагдав.

32 Мөнхүү улиран тохиох дор тийн энэ он төгсөв. Мөн дээрэмчид нэмэгдэж мөн хүчтэй болсоор байв, үүний хэрээр тэд нифайчуудын мөн түүнчлэн леменчүүдийн бүх их цэргийг эсэргүүцэв; мөн тэд уг нутгийн бүх гадаргуу дээрх хүмүүст агуу айдас авчрав.

33 Тийм ээ, учир нь тэд уг нутгийн олон хэсэгт зочилж, мөн тэдэнд агуу устгалыг үйлдэв; тийм ээ, олныг алав, мөн бусад заримыг нь, тийм ээ, мөн илүү онцгойлон эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг нь аглаг буйдад боолчлолд аваачив.

And they did commit murder and plunder; and then they would retreat back into the mountains, and into the wilderness and secret places, hiding themselves that they could not be discovered, receiving daily an addition to their numbers, inasmuch as there were dissenters that went forth unto them.

And thus in time, yea, even in the space of not many years, they became an exceedingly great band of robbers; and they did search out all the secret plans of Gadianton; and thus they became robbers of Gadianton.

Now behold, these robbers did make great havoc, yea, even great destruction among the people of Nephi, and also among the people of the Lamanites.

And it came to pass that it was expedient that there should be a stop put to this work of destruction; therefore they sent an army of strong men into the wilderness and upon the mountains to search out this band of robbers, and to destroy them.

But behold, it came to pass that in that same year they were driven back even into their own lands. And thus ended the eightieth year of the reign of the judges over the people of Nephi.

And it came to pass in the commencement of the eighty and first year they did go forth again against this band of robbers, and did destroy many; and they were also visited with much destruction.

And they were again obliged to return out of the wilderness and out of the mountains unto their own lands, because of the exceeding greatness of the numbers of those robbers who infested the mountains and the wilderness.

And it came to pass that thus ended this year. And the robbers did still increase and wax strong, insomuch that they did defy the whole armies of the Nephites, and also of the Lamanites; and they did cause great fear to come unto the people upon all the face of the land.

Yea, for they did visit many parts of the land, and did do great destruction unto them; yea, did kill many, and did carry away others captive into the wilderness, yea, and more especially their women and their children.

- 34 Эдүгээ тэдний алдсын нь учир уг хүмүүст ирсэн энэ агуу хилэнц тэднийг Их Эзэн Бурханаа санахад дахин өдөөн хатгав.
- 35 Мөн шүүгчдийн засаглалын наяннэгдүгээр он тийн төгсөв.
- 36 Мөн наянхоёрдугаар онд тэд Их Эзэн Бурханаа дахин мартаж эхлэв. Мөн наянгуравдугаар онд тэд алдаст хүчирхэг болж эхлэв. Мөн наядөрөвдүгээр онд ч тэд замуудаа өөрчлөн зассангүй.
- 37 Мөнхүү улиран тохиох дор наянтавдугаар онд тэд бардамналдаа, мөн ёс бус үйлүүдэд улам улам хүчирхэг болж; мөн тэд тийн устгалын тулд дахин боловсорч гүйцэж байв.
- 38 Мөн наянтавдугаар он тийн төгсөв.

Now this great evil, which came unto the people because of their iniquity, did stir them up again in remembrance of the Lord their God.

And thus ended the eighty and first year of the reign of the judges.

And in the eighty and second year they began again to forget the Lord their God. And in the eighty and third year they began to wax strong in iniquity. And in the eighty and fourth year they did not mend their ways.

And it came to pass in the eighty and fifth year they did wax stronger and stronger in their pride, and in their wickedness; and thus they were ripening again for destruction.

And thus ended the eighty and fifth year.

## Хиламан 12

- 1 Мөн хүмүүний үрс ямар хуурамч, мөн түүнчлэн зүрх сэтгэл нь тогтворгүй болохыг бид тийн болгоож чадах буюу; тийм ээ, Их Эзэн өөрт нь найдлага тавьдаг тэднийг хэмжээлшгүй агуу сайн сайхнаараа адисалж мөн дэгжүүлэхийг бид харж чадна.
- 2 Тийм ээ, мөн тэрээр өөрийн хүмүүсийг дэгжүүлэх чухам үед, тийм ээ, талбайг нь, бог болон бод малыг нь, мөн алт, мөн мөнгө, мөн бүх төрлийн мөн янз бүрийн уран хийц бүхий үнэт зүйлсийг зүйл бүрээр нь нэмэгдүүлэхэд; амийг нь хэлтрүүлж, мөн тэднийг дайснаудынх нь гараас чөлөөлөхөд; тэдний эсрэг дайн зарлахгүй байлгахын тулд дайснаудынх нь зүрхийг зөөллөхөд; тийм ээ, эцэст нь өөрийн хүмүүсийн сайн сайхан болон аз жаргалын төлөө бүх зүйлийг тэрээр хийхэд; тийм ээ, тэгэхэд тэд зүрх сэтгэлээ хатууруулж, мөн Их Эзэн Бурханаа мартаж, мөн Ариун Нэгэнийг хөл дороо дэвсэлдэг тийм цаг үе байдгийг бид харж болох бөлгөө—тийм ээ, мөн энэ нь тэдний амар хөнгөн амьдрал, мөн тэдний үлэмж агуу дэгжлийн учир бөлгөө.
- 3 Мөн тийн бид Их Эзэн өөрийн хүмүүсийг олон зовлонгоор цээрлүүлэхгүй бол, тийм ээ, тэр тэдэнд үхлээр мөн аймшгаар, мөн өлсгөлөн болон бүх төрлийн тахлаар зочлохгүй бол, тэд түүнийг санадаггүйг бид ийн харлаа.
- 4 Ай ямар мунхаг, мөн ямар хоосон, мөн ямар хилэнцэт, мөн чөтгөр шиг, мөн алдсыг үйлдэхдээ хичнээн хурдан, мөн сайныг үйлдэхдээ хичнээн удаан билээ, хүмүүний үрс; тийм ээ, хилэнцэт нэгний үгийг сонсохдоо, мөн зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр тавихдаа хичнээн хурдан билээ!
- 5 Тийм ээ, бардамналд хөөрөхдөө хичнээн хурдан бэ; тийм ээ, сагсуурахдаа, мөн алдас болох түүний бүх төрлийг хийхдээ хичнээн хурдан билээ; мөн Их Эзэн Бурханаа санахдаа, мөн түүний зөвлөмжүүдэд чих тавихдаа хичнээн удаан, тийм ээ, мэргэн ухааны замуудаар алхахдаа хичнээн удаан билээ!

## Helaman 12

And thus we can behold how false, and also the unsteadiness of the hearts of the children of men; yea, we can see that the Lord in his great infinite goodness doth bless and prosper those who put their trust in him.

Yea, and we may see at the very time when he doth prosper his people, yea, in the increase of their fields, their flocks and their herds, and in gold, and in silver, and in all manner of precious things of every kind and art; sparing their lives, and delivering them out of the hands of their enemies; softening the hearts of their enemies that they should not declare wars against them; yea, and in fine, doing all things for the welfare and happiness of his people; yea, then is the time that they do harden their hearts, and do forget the Lord their God, and do trample under their feet the Holy One—yea, and this because of their ease, and their exceedingly great prosperity.

And thus we see that except the Lord doth chasten his people with many afflictions, yea, except he doth visit them with death and with terror, and with famine and with all manner of pestilence, they will not remember him.

O how foolish, and how vain, and how evil, and devilish, and how quick to do iniquity, and how slow to do good, are the children of men; yea, how quick to hearken unto the words of the evil one, and to set their hearts upon the vain things of the world!

Yea, how quick to be lifted up in pride; yea, how quick to boast, and do all manner of that which is iniquity; and how slow are they to remember the Lord their God, and to give ear unto his counsels, yea, how slow to walk in wisdom's paths!

6 Болгоогтун, өөрсдийг нь бүтээсэн Их Эзэн  
Бурхан нь өөрсдийнх нь дээр захирахыг мөн засагла-  
хыг тэд хүсдэггүй; тэдэнд түүний хандуулах агуу сайн  
сайхан хийгээд нигүүлсэл байсан хэдий ч, тэд түүний  
зөвлөмжүүдийг үл ойшоодог, мөн тэд түүнийг өөрс-  
дийг нь хөтлөн дагуулагчаа байлгахыг хүсдэггүй.

7 Ай хүмүүний үрс юу ч биш нь ямар агуу их билээ;  
тийм ээ, тэд бүр газрын тоосноос ч өчүүхэн билээ.

8 Учир нь болгоогтун, газрын тоос бидний агуу их  
мөн үүрдийн Бурханы зарлигаар, хоёр хуваагдах  
хүртлээ нааш цааш хөдөлдөг.

9 Тийм ээ, түүний дуунаар толгод болон уулс дор-  
гиж мөн хөдөлдгийг болгоогтун.

10 Мөн түүний дуу хоолойн хүчээр тэдгээр нь ха-  
гарч, мөн тал болно, тийм ээ, бүр хөндий адил бол-  
но.

11 Тийм ээ, түүний дуу хоолойн хүчээр бүхэл газар  
сэгсрэгдэх ажгуу;

12 Тийм ээ, түүний дуу хоолойн хүчээр суурь нь, бүр  
чухамхүү төвдөө хүртэл хөдөлдөг.

13 Тийм ээ, хэрэв тэрээр газарт хандан хэлж—Нүү—  
гэвэл энэ нь нүүнэ.

14 Тийм ээ, хэрэв тэрээр дэлхийд хандан хэлж—өд-  
рийг олон цагаар уртасгахын тул, чи буцаж яв—гэ-  
вэл, энэ нь хийгдсэн байна;

15 Мөн тийн, түүний үгийн дагуу дэлхий буцаж яв-  
на, мөн энэ нь хүмүүнд нар хөдөлгөөнгүй зогсох мэт  
үзэгдэх бөлгөө; тийм ээ, мөн болгоогтун, энэ нь  
үүнчлэн байдаг; учир нь нар бус харин дэлхий хөдөл-  
дөг нь гарцаагүй юм.

16 Мөн болгоогтун, түүнчлэн, хэрэв тэрээр агуу их  
гүний усанд хэлж—чи хат—гэвэл энэ нь хийгдсэн  
байна.

17 Болгоогтун, хэрэв тэрээр энэ ууланд—чи өргөгд  
гэвэл, мөн энэ нь булшлагадхын тулд, тэр хотын дээр  
ирж мөн унагтун—гэвэл болгоогтун энэ нь хийгдэ-  
нэ.

18 Мөн болгоогтун, хэрэв хүн эрдэнэсийг газарт нуу-  
хад, мөн—энэ нь үүнийг нуусан түүний алдсын учир  
зүхэгдэг—хэмээн Их Эзэн хэлбэл болгоогтун, энэ нь  
зүхэгдэх болно.

Behold, they do not desire that the Lord their God,  
who hath created them, should rule and reign over  
them; notwithstanding his great goodness and his  
mercy towards them, they do set at naught his counsels,  
and they will not that he should be their guide.

O how great is the nothingness of the children of  
men; yea, even they are less than the dust of the earth.

For behold, the dust of the earth moveth hither and  
thither, to the dividing asunder, at the command of our  
great and everlasting God.

Yea, behold at his voice do the hills and the moun-  
tains tremble and quake.

And by the power of his voice they are broken up,  
and become smooth, yea, even like unto a valley.

Yea, by the power of his voice doth the whole earth  
shake;

Yea, by the power of his voice, do the foundations  
rock, even to the very center.

Yea, and if he say unto the earth—Move—it is  
moved.

Yea, if he say unto the earth—Thou shalt go back,  
that it lengthen out the day for many hours—it is done;

And thus, according to his word the earth goeth  
back, and it appeareth unto man that the sun standeth  
still; yea, and behold, this is so; for surely it is the earth  
that moveth and not the sun.

And behold, also, if he say unto the waters of the  
great deep—Be thou dried up—it is done.

Behold, if he say unto this mountain—Be thou raised  
up, and come over and fall upon that city, that it be  
buried up—behold it is done.

And behold, if a man hide up a treasure in the earth,  
and the Lord shall say—Let it be accursed, because of  
the iniquity of him who hath hid it up—behold, it shall  
be accursed.

- 19 Мөн хэрэв—энэ цагаас хойш мөн үүрд хэн ч чамайг олохгүй байхын тулд чи зүхэгдэг—хэмээн Их Эзэн хэлбэл, болгоогтун, хэн ч тэр цагаас хойш мөн үүрд үүнийг авахгүй.
- 20 Мөн болгоогтун, хэрэв—Алдсуудын учир, чи үүрд зүхэгдэх болно—хэмээн Их Эзэн хүнд хэлбэл энэ нь хийгдэх болно.
- 21 Мөн хэрэв—Алдсуудынхаа учир чи дэргэдээс минь тусгаарлагдах болно—хэмээн Их Эзэн хэлбэл тэрээр үүнийг түүнчлэн байхаар болгох болно.
- 22 Тэрээр үүнийг хэнд хэлнэв, түүнд халаг байна, учир нь алдсыг үйлдэх түүнд л байх болно, мөн тэрээр аврагдаж чадахгүй; тиймийн тул, хүмүүн аврагдаж болох энэхүү шалтгааны учир, наманчлал тунхаглагдсан юм.
- 23 Тиймийн тул, наманчлах мөн Их Эзэн Бурханыхаа дуу хоолойг анхааран сонсдог тэд адислагдсан байдаг; учир нь тэд бол аврагдах тэд билээ.
- 24 Мөн хүмүүн наманчлалд хийгээд сайн ажлуудад авчрагдаж болохыг, тэд үйлүүдийнхээ дагуу ач ивээлийн тулд ач ивээлд сэргээгдэж болохыг Бурхан агуу их бүрэн байдлаараа соёрхох болтугай.
- 25 Мөн бүх хүмүүн аврагдах болоосой хэмээнэ би. Гэвч бидний уншдагчлан агуу их хийгээд эцсийн өдөр зайлуулагдах, тийм ээ, Их Эзэний дэргэдээс тусгаарлагдах зарим нь байх болно;
- 26 Тийм ээ, төгсгөлгүй аймшгийн байдалд хүргэгдэх тэд энэхүү үгсийг гүйцэлдүүлэх болно: Сайныг хийсэн нь үүрдийн амьдралыг авах болно; мөн хилэнцийг хийсэн нь үүрдийн ял авах болно. Мөн энэ нь тийн болой. Амен.

And if the Lord shall say—Be thou accursed, that no man shall find thee from this time henceforth and forever—behold, no man getteth it henceforth and forever.

And behold, if the Lord shall say unto a man—Because of thine iniquities, thou shalt be accursed forever—it shall be done.

And if the Lord shall say—Because of thine iniquities thou shalt be cut off from my presence—he will cause that it shall be so.

And wo unto him to whom he shall say this, for it shall be unto him that will do iniquity, and he cannot be saved; therefore, for this cause, that men might be saved, hath repentance been declared.

Therefore, blessed are they who will repent and hearken unto the voice of the Lord their God; for these are they that shall be saved.

And may God grant, in his great fulness, that men might be brought unto repentance and good works, that they might be restored unto grace for grace, according to their works.

And I would that all men might be saved. But we read that in the great and last day there are some who shall be cast out, yea, who shall be cast off from the presence of the Lord;

Yea, who shall be consigned to a state of endless misery, fulfilling the words which say: They that have done good shall have everlasting life; and they that have done evil shall have everlasting damnation. And thus it is. Amen.

### Хиламан 13

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор наян зургадугаар онд леменчүүд Мосегийн хуулийн дагуу, Бурханы зарлигуудыг дагахаар чандлан хичээж байх үед, нифайчууд ёс бус үйлүүддээ, тийм ээ, агуу ёс бус үйлэнд хэвээр үлдэв, бөлгөө.
- 2 Мөнхүү улиран тохиох дор энэхүү онд лемен үндэстэн Самуел гэгч нэгэн, Зарахемла нутагт ирж, мөн хүмүүст номлож эхлэв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр, хүмүүст наманчлалыг олон өдөр номлож, мөн тэд түүнийг хөөж гарган, мөн тэрээр нутагтаа буцах гэж байв.
- 3 Гэвч болгоогтун, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, түүнийг дахин эргэн очиж, мөн зүрх сэтгэлд нь ирэх аливаа зүйлийг хүмүүст бошиглохыг хэлэв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнийг хотод орохыг зөвшөөрсөнгүй; тиймийн тул тэрээр явж мөн үүний хэрмэн дээр гарч, мөн гараа дэлгэн мөн чанга дуугаар хашгирч, мөн Их Эзэн зүрх сэтгэлд нь өгсөн аливаа зүйлийг хүмүүст бошиглов.
- 5 Мөн тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, би, Самуел, лемен үндэстэн, Их Эзэн зүрх сэтгэлд минь өгсөн түүний үгсийг ярья; мөн болгоогтун тэрээр шударга ёсны илд энэ хүмүүсийн дээр далайгаастай байгааг энэ хүмүүст хэлэхийг зүрх сэтгэлд минь өглөө; мөн шударга ёсны илд энэ хүмүүсийн дээр буух хүртэл дөрвөн зуун жил улиран одохгүй бөлгөө.
- 6 Тийм ээ, дэлхийд гарцаагүй ирэх, мөн энэ хүмүүсийн төлөө олон зүйлийг тэвчиж мөн егүүтгэгдэх, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл мөн наманчлалаас өөр юу ч энэ хүмүүсийг аварч чадахгүй, мөн энэ хүмүүсийг хүнд бэрх устгал хүлээж байна, мөн энэ нь энэ хүмүүсийн дээр гарцаагүй ирэх болно.
- 7 Мөн болгоогтун, Их Эзэний нэгэн тэнгэр элч надад үүнийг тунхаглаж, мөн тэрээр бодгальд минь баярт мэдээ авчирсан болой. Мөн болгоогтун, та нарт ч баярт мэдээ байж болохын тулд үүнийг та нарт түүнчлэн тунхаглахаар илгээгдсэн болой би; гэвч болгоогтун та нар намайг хүлээн авсангүй.

### Helaman 13

And now it came to pass in the eighty and sixth year, the Nephites did still remain in wickedness, yea, in great wickedness, while the Lamanites did observe strictly to keep the commandments of God, according to the law of Moses.

And it came to pass that in this year there was one Samuel, a Lamanite, came into the land of Zarahemla, and began to preach unto the people. And it came to pass that he did preach, many days, repentance unto the people, and they did cast him out, and he was about to return to his own land.

But behold, the voice of the Lord came unto him, that he should return again, and prophesy unto the people whatsoever things should come into his heart.

And it came to pass that they would not suffer that he should enter into the city; therefore he went and got upon the wall thereof, and stretched forth his hand and cried with a loud voice, and prophesied unto the people whatsoever things the Lord put into his heart.

And he said unto them: Behold, I, Samuel, a Lamanite, do speak the words of the Lord which he doth put into my heart; and behold he hath put it into my heart to say unto this people that the sword of justice hangeth over this people; and four hundred years pass not away save the sword of justice falleth upon this people.

Yea, heavy destruction awaiteth this people, and it surely cometh unto this people, and nothing can save this people save it be repentance and faith on the Lord Jesus Christ, who surely shall come into the world, and shall suffer many things and shall be slain for his people.

And behold, an angel of the Lord hath declared it unto me, and he did bring glad tidings to my soul. And behold, I was sent unto you to declare it unto you also, that ye might have glad tidings; but behold ye would not receive me.



- 8 Тиймийн тул, Их Эзэн ийн хэлэв: Тэд наманчлахгүй аваас нифайчуудын ард түмний зүрх сэтгэл хатуугийн учир, би өөрийн үгийг тэднээс татан авна, мөн би Сүнсээ тэднээс буцааж авах болно, мөн би тэднийг цаашид тэвчихгүй, мөн ах дүүсийнх нь зүрх сэтгэлийг тэдний эсрэг эргүүлэх болно би.
- 9 Мөн би тэднийг цохигдохоор болгохоос өмнө дөрвөн зуун жил улиран өнгөрөхгүй; тийм ээ, би тэдэнд илдээр мөн өлсгөлөнгөөр мөн тахлаар зочлох болно.
- 10 Тийм ээ, би тэдэнд догшин уур хилэнгээрээ зочлох болно, мөн дайснуудын чинь дөрөв дэх үеийнхнээс та нарын бүрмөсөн устгалыг болгоохоор амьд үлдэх тэд байх болно; мөн та нар наманчлахгүй аваас гарцаагүй ирэх болно хэмээн Их Эзэн хэлсэн билээ; мөн дөрөв дэх үеийнхний тэд та нарт устгалаар зочлох болно.
- 11 Гэвч та нар наманчилж мөн Их Эзэн Бурхандаа хандах аваас, би уур хилэнгээ зайлуулах болно хэмээн Их Эзэн хэлдэг; тийм ээ, наманчлах мөн надад хандах тэд адислагдсан болой, харин наманчлахгүй түүнд халаг байх болно хэмээн Их Эзэн тийн хэлдэг.
- 12 Тийм ээ, энэ агуу хот Зарахемлад халаг; учир нь болгоогтун, үүний аврагдаж байгаа нь зөв шударгыг үйлдэгсэд тэдний улмаас юм; тийм ээ, энэ агуу хотод халаг, учир нь Их Эзэн хэлнэ, миний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах нь олон байгаа, тийм ээ, энэ агуу хотын бүр ихэнх хэсэг нь болохыг би ухамсарлана хэмээн Их Эзэн хэлж байна.
- 13 Гэвч наманчлах тэд адислагдсан болой, учир нь тэднийг би хэлтрүүлэх болно. Гэвч болгоогтун, хэрэв энэ агуу хотод зөв шударгыг үйлдэгсэд байгаагүй аваас, болгоогтун, би тэнгэрээс доош гал буулган мөн үүнийг устгахаар болгохсон.
- 14 Гэвч болгоогтун, үүний хэлтрүүлэгдэж байгаа нь зөв шударгыг үйлдэгсдийн төлөө болой. Гэвч болгоогтун, та нарын дундаас зөв шударгыг үйлдэгчдийг зайлуулах тэр үед, тэгээд та нар устгалын тулд боловсорч гүйцсэн байх тэр цаг ирэх болно хэмээн Их Эзэн хэлэв; тийм ээ, үүн дэх ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн учир, энэ агуу хотод халаг боллог.

Therefore, thus saith the Lord: Because of the hardness of the hearts of the people of the Nephites, except they repent I will take away my word from them, and I will withdraw my Spirit from them, and I will suffer them no longer, and I will turn the hearts of their brethren against them.

And four hundred years shall not pass away before I will cause that they shall be smitten; yea, I will visit them with the sword and with famine and with pestilence.

Yea, I will visit them in my fierce anger, and there shall be those of the fourth generation who shall live, of your enemies, to behold your utter destruction; and this shall surely come except ye repent, saith the Lord; and those of the fourth generation shall visit your destruction.

But if ye will repent and return unto the Lord your God I will turn away mine anger, saith the Lord; yea, thus saith the Lord, blessed are they who will repent and turn unto me, but wo unto him that repenteth not.

Yea, wo unto this great city of Zarahemla; for behold, it is because of those who are righteous that it is saved; yea, wo unto this great city, for I perceive, saith the Lord, that there are many, yea, even the more part of this great city, that will harden their hearts against me, saith the Lord.

But blessed are they who will repent, for them will I spare. But behold, if it were not for the righteous who are in this great city, behold, I would cause that fire should come down out of heaven and destroy it.

But behold, it is for the righteous' sake that it is spared. But behold, the time cometh, saith the Lord, that when ye shall cast out the righteous from among you, then shall ye be ripe for destruction; yea, wo be unto this great city, because of the wickedness and abominations which are in her.

- 15 Тийм ээ, үүний доторх ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн учир мөн Гидеон хотод халаг болог.
- 16 Тийм ээ, мөн тэдний доторх ёс бус үйлүүд мөн жигшүүрт хэргүүдийн учир, нифайчуудаар эзэмшигдсэн, эргэн тойрны нутаг дахь тэр бүх хотуудад халаг болог.
- 17 Мөн болгоогтун, Түмний Их Эзэн хэлэв, уг нутагт буй хүмүүсээс болж, тийм ээ, тэдний ёс бус үйлүүд мөн тэдний жигшүүрт хэргүүдийн учир зүхэл уг нутгийн дээр ирэх болно.
- 18 Мөнхүү улиран тохиох дор, Түмний Их Эзэн, тийм ээ, агуу их болоод үнэн Бурхан маань хэлдэг, тэр нь зөв шударга хүн байж мөн үүнийг Их Эзэний төлөө нуухаас бусдаар эрдэнэсийг газарт нуусан хэн боловч, уг нутгийн агуу их зүхлийн учир тэдгээрийг дахин хэзээ ч олохгүй.
- 19 Учир нь Их Эзэн хэлдэг, тэд эрдэнэсээ миний төлөө нуугаасай хэмээн хүснэ би; мөн эрдэнэсээ миний төлөө нуугаагүй тэд зүхэгдэх болно; учир нь зөв шударгыг үйлдэгсдээс бусад хэн ч миний төлөө эрдэнэсээ нуудаггүй; мөн эрдэнэсээ миний төлөө нуухгүй түүнд, мөн түүнчлэн уг эрдэнэс нь зүхэгдсэн, уг нутгийн зүхлийн учир юу ч үүнийг гэтэлгэхгүй.
- 20 Мөн тэд зүрх сэтгэлээ баялгууд дээр тавьсан учир, эрдэнэсээ нуух тэр өдөр ирэх болно; мөн тэд зүрх сэтгэлээ баялгуудынхаа дээр тавьсан учир тэд дайснуудынхаа өмнө зугтах үедээ эрдэнэсээ нуух болно; тэд тэдгээрийг миний төлөө нуухгүй учраас, тэд мөн түүнчлэн тэдний эрдэнэс нь ч зүхэгдэг; мөн тэрхүү өдөр тэд цохигдох болно хэмээн Их Эзэн хэлж байна.
- 21 Болгоогтун энэ агуу хотын хүмүүс та нар, мөн үгсийг минь анхааран сонсооч; тийм ээ, Их Эзэний хэлэх үгсийг анхааран сонсоцгоо; учир нь болгоогтун, та нар баялгуудынхаа учир зүхэгдсэн, мөн түүнчлэн та нар зүрх сэтгэлээ тэдгээрийн дээр тавьсан учир, мөн тэдгээрийг та нарт өгсөн түүний үгсийг анхааран сонсоогүй учир баялгууд чинь ч зүхэгдсэн билээ.

Yea, and wo be unto the city of Gideon, for the wickedness and abominations which are in her.

Yea, and wo be unto all the cities which are in the land round about, which are possessed by the Nephites, because of the wickedness and abominations which are in them.

And behold, a curse shall come upon the land, saith the Lord of Hosts, because of the people's sake who are upon the land, yea, because of their wickedness and their abominations.

And it shall come to pass, saith the Lord of Hosts, yea, our great and true God, that whoso shall hide up treasures in the earth shall find them again no more, because of the great curse of the land, save he be a righteous man and shall hide it up unto the Lord.

For I will, saith the Lord, that they shall hide up their treasures unto me; and cursed be they who hide not up their treasures unto me; for none hideth up their treasures unto me save it be the righteous; and he that hideth not up his treasures unto me, cursed is he, and also the treasure, and none shall redeem it because of the curse of the land.

And the day shall come that they shall hide up their treasures, because they have set their hearts upon riches; and because they have set their hearts upon their riches, and will hide up their treasures when they shall flee before their enemies; because they will not hide them up unto me, cursed be they and also their treasures; and in that day shall they be smitten, saith the Lord.

Behold ye, the people of this great city, and hearken unto my words; yea, hearken unto the words which the Lord saith; for behold, he saith that ye are cursed because of your riches, and also are your riches cursed because ye have set your hearts upon them, and have not hearkened unto the words of him who gave them unto you.

- 22 Тэрээр та нарыг адисалсан зүйлүүдэд та нар Их Эзэн Бурханаа санадаггүй, гэвч та нар баялгуудаа үргэлж санаж байдаг, тэдгээрийн төлөө Их Эзэн Бурхандаа талархахын тулд ч бус юм; тийм ээ, та нарын зүрх сэтгэл Их Эзэнд хандахгүй байгаа, харин тэдгээр нь сайрхалд, мөн агуу хөөрөлд, атаа жөтөө, хэрүүл маргаан, өшөө хорсол, хавчлага гадуурхал, мөн аллагууд, мөн бүх төрлийн алдсуудад хүртлээ агуу бардамналд тэлдэг болой.
- 23 Энэ шалтгааны учир Их Эзэн Бурхан зүхлийг ут нутгийн дээр, мөн түүнчлэн та нарын баялгууд дээр ирэх болгосон буюу, мөн энэ нь та нарын алдсуудын учир болой.
- 24 Тийм ээ, бүр хуучин цагийн тэдний хийдэг байсны адилаар та нар бошиглогчдыг зайлуулж, мөн тэднийг элэглэн, мөн тэдний зүг чулуу шидэж, мөн тэднийг хөнөөж, мөн тэдэнд бүх төрлийн алдсыг үйлдэх болсон энэ цагийн учир энэ хүмүүст халаг.
- 25 Мөн эдүгээ та нар ярихдаа: хэрэв бидний өдрүүд хуучны эцэг өвгөдийн минь өдрүүдэд байсан бол, бид бошиглогчдыг алахгүй байсан; бид тэдний зүг чулуу шидэж, мөн тэднийг зайлуулахгүй байсан хэмээн та нар хэлдэг.
- 26 Болгоогтун та нар тэднээс ч дор; учир нь Их Эзэн амьдын адил, хэрэв та нарын дунд бошиглогч ирж мөн та нарын нүглүүд хийгээд алдсуудыг гэрчилсэн, Их Эзэний үгийг та нарт тунхаглах аваас, та нар түүнд уурлаж, мөн түүнийг зайлуулж мөн түүнийг устгах бүх төрлийн арга замуудыг эрэлхийлдэг; тийм ээ, тэрээр та нарын үйлүүдийг хилэнцэт хэмээн гэрчилдэг учир та нар тэр бол хуурамч бошиглогч, мөн тэр бол нүгэлтэн, мөн чөтгөрийнх хэмээн хэлэх болно.
- 27 Гэвч болгоогтун, хэрэв нэгэн хүн та нарын дунд ирж: Үүнийг хий, мөн алдас гэж үгүй; түүнийг үйлд мөн та нар зовох нь үгүй гэж хэлбэл; тийм ээ: Зүрх сэтгэлдээ бардамналтайгаар алх; тийм ээ, харцандаа бардамналтайгаар алх, мөн зүрх сэтгэлийнхээ хүссэн юуг ч боловч үйлд гэж тэр хэлбэл—мөн хэрэв нэгэн хүн та нарын дунд ирж үүнийг хэлбэл, та нар түүнийг хүлээн авч, мөн түүнийг бошиглогч гэж хэлэх болно.

Ye do not remember the Lord your God in the things with which he hath blessed you, but ye do always remember your riches, not to thank the Lord your God for them; yea, your hearts are not drawn out unto the Lord, but they do swell with great pride, unto boasting, and unto great swelling, envyings, strifes, malice, persecutions, and murders, and all manner of iniquities.

For this cause hath the Lord God caused that a curse should come upon the land, and also upon your riches, and this because of your iniquities.

Yea, wo unto this people, because of this time which has arrived, that ye do cast out the prophets, and do mock them, and cast stones at them, and do slay them, and do all manner of iniquity unto them, even as they did of old time.

And now when ye talk, ye say: If our days had been in the days of our fathers of old, we would not have slain the prophets; we would not have stoned them, and cast them out.

Behold ye are worse than they; for as the Lord liveth, if a prophet come among you and declareth unto you the word of the Lord, which testifieth of your sins and iniquities, ye are angry with him, and cast him out and seek all manner of ways to destroy him; yea, you will say that he is a false prophet, and that he is a sinner, and of the devil, because he testifieth that your deeds are evil.

But behold, if a man shall come among you and shall say: Do this, and there is no iniquity; do that and ye shall not suffer; yea, he will say: Walk after the pride of your own hearts; yea, walk after the pride of your eyes, and do whatsoever your heart desireth—and if a man shall come among you and say this, ye will receive him, and say that he is a prophet.

28 Тийм ээ, та нар түүнийг өргөмжлөх болно, мөн та нар түүнд хөрөнгөнөөсөө өгөх болно; та нар түүнд алтнаасаа, мөн мөнгөнөөсөө өгөх болно, мөн та нар түүнийг үнэт хувцас хунараар хувцаслах болно; мөн тэрээр зусарч үгсийг та нарт ярина, мөн бүгд зүгээр гэж хэлэх учир, тийнхүү та нар түүнээс бурууг олохгүй байх болно.

29 Ай ёс бус та нар мөн тэрслүүд үеийнхэн та нар; хатуурхсан та нар мөн зөрүүд хүмүүс та нар, Их Эзэн та нарыг хэр удаан тэвчинэ гэж та нар бодож байна? Тийм ээ, та нар өөрсдийгөө мунхаг мөн харалган удирдагчдаар дагуулагдахыг хэр удаан тэвчих билээ? Тийм ээ, та нар гэрлээс илүүтэйгээр харанхуйг хэр удаан сонгох билээ

30 Тийм ээ, болгоогтун, Их Эзэний уур хилэн аль хэдийн та нарын эсрэг шатаж байна; болгоогтун, тэрээр уг нутгийг алдсын чинь учир зүхсэн билээ.

31 Мөн болгоогтун, тэдгээр нь гулгамтгай болсноос та нар тэдгээрийг барьж байж чадахгүйн улмаас, тэрээр баялгуудыг чинь зүхэх тэр цаг ирэх болно; мөн ядуурлынхаа өдрүүдэд та нар тэдгээрийг хадгалан үлдээж чадахгүй.

32 Мөн ядуурлынхаа өдрүүдэд та нар Их Эзэнд гуйн залбирах болно; мөн та нар хоосон залбиран гуйх болно, учир нь хоосрол тань аль хэдийн та нарын дээр ирнэ, мөн устгал тань гарцаагүй хийгдэх болно; мөн тэгээд тэр өдөр та нар уйлж мөн гаслах болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг. Мөн тэгэхэд та нар гашуудах болно, мөн өгүүлэн:

33 Ай би наманчилсан болоосой мөн бошиглогчдыг алаагүй, тэдний зүг чулуу шидээгүй, мөн тэднийг зайлуулаагүй болоосой. Тийм ээ, тэр өдөр та нар хэлэх болно: Ай тэрээр баялгуудыг маань өгсөн тэр өдөр Их Эзэн Бурханаа бид санасан ч болоосой, мөн тэгээд гулгамтгай болсноос бид тэдгээрийг алдахгүйсэн; учир нь болгоогтун, баялгууд маань биднээс үгүй болжээ.

34 Болгоогтун, бид багажаа энд тавихад мөн маргааш нь энэ нь үгүй болсон байна; мөн болгоогтун, илднүүд маань бид тулалдахын тулд тэдгээрийг эрэлхийлсэн тэр өдөр биднээс авагдсан байна.

35 Тийм ээ, уг нутгийн зүхлийн учир, бид эрдэнэсээ нуугаад мөн тэдгээр нь биднээс гулган зайлав.

Yea, ye will lift him up, and ye will give unto him of your substance; ye will give unto him of your gold, and of your silver, and ye will clothe him with costly apparel; and because he speaketh flattering words unto you, and he saith that all is well, then ye will not find fault with him.

O ye wicked and ye perverse generation; ye hardened and ye stiffnecked people, how long will ye suppose that the Lord will suffer you? Yea, how long will ye suffer yourselves to be led by foolish and blind guides? Yea, how long will ye choose darkness rather than light?

Yea, behold, the anger of the Lord is already kindled against you; behold, he hath cursed the land because of your iniquity.

And behold, the time cometh that he curseth your riches, that they become slippery, that ye cannot hold them; and in the days of your poverty ye cannot retain them.

And in the days of your poverty ye shall cry unto the Lord; and in vain shall ye cry, for your desolation is already come upon you, and your destruction is made sure; and then shall ye weep and howl in that day, saith the Lord of Hosts. And then shall ye lament, and say:

O that I had repented, and had not killed the prophets, and stoned them, and cast them out. Yea, in that day ye shall say: O that we had remembered the Lord our God in the day that he gave us our riches, and then they would not have become slippery that we should lose them; for behold, our riches are gone from us.

Behold, we lay a tool here and on the morrow it is gone; and behold, our swords are taken from us in the day we have sought them for battle.

Yea, we have hid up our treasures and they have slipped away from us, because of the curse of the land.

- 36 Ай Их Эзэний үг бидэнд ирсэн тэр өдөр бид наманчилсан ч болоосой; учир нь болгоогтун уг нутаг зүхэгдсэн, мөн бүх зүйл гулгамтгай болж, мөн бид тэдгээрийг барьж чадахгүй болов.
- 37 Болгоогтун, бид чөтгөрүүдээр хүрээлэгдсэн, тийм ээ, бодгалиудыг маань устгахыг эрэлхийлэх түүний элчүүдээр бид бүслэгдэв. Болгоогтун, алдсууд маань агуу их. Ай Их Эзэн, та уур хилэнгээ биднээс зайлуулж болохгүй юу? Мөн энэ нь тэр өдрүүдэд та нарын өгүүлэх зүйл байх болно.
- 38 Гэвч болгоогтун, сорилтын чинь өдрүүд өнгөрсөн; та нар авралынхаа өдрийг энэ нь бүрмөсөн дэндүү оройтох хүртэл хойшлуулсан, мөн устгал чинь гарцаагүй болсон билээ; тийм ээ, учир нь та нар амьдралынхаа бүх өдрүүдэд хүрч чадахгүй түүнийг эрэлхийлсэн; мөн та нар алдсыг үйлдэж аз жаргалыг эрэлхийлсэн нь бидний агуу их Мөнхийн Тэргүүнд байх зөв шударга чанарын эсрэг юм.
- 39 Ай уг нутгийн хүмүүс та нар, үгсийг минь сонсоосой! Мөн Их Эзэний уур хилэн та нараас зайлуулагдаж, мөн та нар наманчилж мөн аврагдаасай хэмээн залбирна би.

O that we had repented in the day that the word of the Lord came unto us; for behold the land is cursed, and all things are become slippery, and we cannot hold them.

Behold, we are surrounded by demons, yea, we are encircled about by the angels of him who hath sought to destroy our souls. Behold, our iniquities are great. O Lord, canst thou not turn away thine anger from us? And this shall be your language in those days.

But behold, your days of probation are past; ye have procrastinated the day of your salvation until it is everlastingly too late, and your destruction is made sure; yea, for ye have sought all the days of your lives for that which ye could not obtain; and ye have sought for happiness in doing iniquity, which thing is contrary to the nature of that righteousness which is in our great and Eternal Head.

O ye people of the land, that ye would hear my words! And I pray that the anger of the Lord be turned away from you, and that ye would repent and be saved.

## Хиламан 14

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор лемен үндэстэн тэрхүү Самуел, бичигдэх аргагүй илүү олон агуу зүйлийг бошиглов.
- 2 Мөн болгоогтун, тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, би та нарт тэмдэг өгье; учир нь дахин таван жил өнгөрөхөд, мөн болгоогтун, тэгэхэд Бурханы Хүү өөрийнх нь нэрэнд итгэх тэд бүгдийг гэтэлгэхээр ирэх болно.
- 3 Мөн болгоогтун, түүний ирэлтийн үеийн тэмдэг болгон би үүнийг та нарт өгөх болно; учир нь болгоогтун, тэнгэрт агуу гэрлүүд байх болно, үүний хэрээр түүнийг ирэхийн өмнөх шөнө харанхуй болохгүй, үүний хэрээр энэ нь хүмүүнд өдөр мэт үзэгдэх болно.
- 4 Тиймийн тул, нэг өдөр мөн шөнө мөн өдөр, шөнөгүй нэгэн өдөр лугаа адил байх болно; мөн энэ нь та нарт тэмдэг байх болно; учир нь та нар нар ургачыг мөн түүнчлэн шингэхийг нь мэдэх болно; тиймийн тул тэд хоёр өдөр мөн нэг шөнө болохыг гарцаагүй мэдэх болно; гэсэн хэдий ч шөнө нь харанхуйлахгүй; мөн энэ нь түүний төрөхийн өмнөх шөнө байх болно.
- 5 Мөн болгоогтун, та нарын хэзээ ч тийм нэгнийг болгоогүй тэрхүү нэгэн шинэ од гарах болно; мөн энэ нь түүнчлэн та нарт тэмдэг байх болно.
- 6 Мөн болгоогтун энэ нь бүгд бус, тэнгэрт олон тэмдэг мөн гайхамшгууд байх болно.
- 7 Мөнхүү улиран тохиох дор та нар бүгд бахдаж мөн гайхах болно, үүний хэрээр та нар газарт унах болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Бурханы Хүүд итгэх хэн боловч, мөнхүү тэр нь үүрдийн амьдралыг авах болно.
- 9 Мөн болгоогтун, намайг ирж мөн энэ зүйлийг та нарт хэлэх ёстой хэмээн, Их Эзэн өөрийн тэнгэр элчээр надад ийн зарлигласан билээ; тийм ээ, тэрээр эдгээр зүйлийг намайг та нарт бошиглохыг зарлигласан болой; тийм ээ, тэрээр надад: Энэ хүмүүст наманчилж мөн Их Эзэний замыг бэлтгэ хэмээн хашгир гэсэн билээ.

## Helaman 14

And now it came to pass that Samuel, the Lamanite, did prophesy a great many more things which cannot be written.

And behold, he said unto them: Behold, I give unto you a sign; for five years more cometh, and behold, then cometh the Son of God to redeem all those who shall believe on his name.

And behold, this will I give unto you for a sign at the time of his coming; for behold, there shall be great lights in heaven, insomuch that in the night before he cometh there shall be no darkness, insomuch that it shall appear unto man as if it was day.

Therefore, there shall be one day and a night and a day, as if it were one day and there were no night; and this shall be unto you for a sign; for ye shall know of the rising of the sun and also of its setting; therefore they shall know of a surety that there shall be two days and a night; nevertheless the night shall not be darkened; and it shall be the night before he is born.

And behold, there shall a new star arise, such an one as ye never have beheld; and this also shall be a sign unto you.

And behold this is not all, there shall be many signs and wonders in heaven.

And it shall come to pass that ye shall all be amazed, and wonder, insomuch that ye shall fall to the earth.

And it shall come to pass that whosoever shall believe on the Son of God, the same shall have everlasting life.

And behold, thus hath the Lord commanded me, by his angel, that I should come and tell this thing unto you; yea, he hath commanded that I should prophesy these things unto you; yea, he hath said unto me: Cry unto this people, repent and prepare the way of the Lord.

- 10 Мөн эдүгээ, би лемен үндэстэн, мөн Их Эзэний надад зарлигласан үгсийг та нарт ярьсан учир, мөн энэ нь та нарын эсрэг хатуу байсан учир, та нар надад уурлаж мөн намайг устгахаар эрэлхийлж байна, мөн өөрсдийн дундаас намайг хөөн зайлуулсан болой.
- 11 Мөн та нар үгсийг сонсох миний болно, учир нь, энэ зорилгын тулд би энэ хотын хэрмэн дээр гарсан, алдсуудын чинь учир та нарыг хүлээх Бурханы шүүлтийн талаар та нар сонсож мөн мэдэж болохын тулд, мөн түүнчлэн та нар наманчлалын нөхцөлийг мэдэж болохын тулд болой.
- 12 Мөн түүнчлэн эхлэлээс бүх зүйлийг Бүтээгч, тэнгэрийн болон газрын Эцэг, Бурханы Хүү, Есүс Христийн ирэлтийн тухай та нар мэдэж болохын тулд; мөн та нар түүний нэрэнд итгэж болох тэрхүү зорилгын тулд та нар түүний ирэлтийн тэмдгүүдийн талаар мэдэж болохын тулд бөлгөө.
- 13 Мөн хэрэв та нар түүний нэрэнд итгэвэл бүх нүглүүдээ наманчилж, тэгснээр та нар тэдгээрийн ангижралыг түүний сайн үйлээр дамжуулан олж болно.
- 14 Мөн болгоогтун, тэрчлэн, бас нэг тэмдэг, тийм ээ, түүний үхлийн тэмдгийг би та нарт өгье.
- 15 Учир нь болгоогтун, аврал ирж болохын тулд тэрээр гарцаагүй үхэх ёстой; тийм ээ, хүмүүн Их Эзэний дэргэд авчрагдаж болохын тулд, нас барагсдын амилуулалт улиран тохиоход түүний үхэх нь түүнд зохих ёсны хийгээд зайлшгүй зүйл билээ.
- 16 Тийм ээ, болгоогтун, энэ үхэл амилуулалтыг улируулан тохиолгож, мөн эхний үхлээс—сүнсний үхлээс бүх хүн төрөлхтнийг гэтэлгэнэ; учир нь бүх хүн төрөлхтөн, Адамын уналтаар Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан учир, биеийн зүйлүүд мөн сүнсний зүйлүүдийн аль алианаар нь үхмэлд тооцогдсон бөлгөө.
- 17 Гэвч болгоогтун, Христийн амилалт хүн төрөлхтнийг, тийм ээ, бүр бүх хүн төрөлхтнийг гэтэлгэнэ, мөн тэднийг Их Эзэний дэргэд буцааж авчрах болно.

And now, because I am a Lamanite, and have spoken unto you the words which the Lord hath commanded me, and because it was hard against you, ye are angry with me and do seek to destroy me, and have cast me out from among you.

And ye shall hear my words, for, for this intent have I come up upon the walls of this city, that ye might hear and know of the judgments of God which do await you because of your iniquities, and also that ye might know the conditions of repentance;

And also that ye might know of the coming of Jesus Christ, the Son of God, the Father of heaven and of earth, the Creator of all things from the beginning; and that ye might know of the signs of his coming, to the intent that ye might believe on his name.

And if ye believe on his name ye will repent of all your sins, that thereby ye may have a remission of them through his merits.

And behold, again, another sign I give unto you, yea, a sign of his death.

For behold, he surely must die that salvation may come; yea, it behooveth him and becometh expedient that he dieth, to bring to pass the resurrection of the dead, that thereby men may be brought into the presence of the Lord.

Yea, behold, this death bringeth to pass the resurrection, and redeemeth all mankind from the first death—that spiritual death; for all mankind, by the fall of Adam being cut off from the presence of the Lord, are considered as dead, both as to things temporal and to things spiritual.

But behold, the resurrection of Christ redeemeth mankind, yea, even all mankind, and bringeth them back into the presence of the Lord.

- 18 Тийм ээ, наманчлалын нөхцөлийг хангаснаас, наманчлах хэн боловч тэр нь тас цавчигдаж мөн галд хаягдахгүй; харин наманчлахгүй хэн боловч тас цавчигдаж мөн галд хаягдах болно; мөн тэдний дээр сүнсний үхэл дахин ирнэ, тийм ээ, хоёр дахь үхэл, учир нь тэд зөв шударгад хамаарагдах зүйлүүдийн хувьд дахин тусгаарлагдах болно.
- 19 Тиймийн тул наманчлагтун та нар, наманчлагтун та нар, эдгээр зүйлийг мэдээд мөн эдгээрийг хийхгүй байснаар та нар өөрсдөө буруушаагдахыг хүлцдэг, мөн энэ хоёр дахь үхэлд та нар доош хүргэгдэх болузай.
- 20 Гэвч болгоогтун, өөр нэг тэмдэг, түүний үхлийн тэмдгийн талаар та нарт миний хэлсэнчлэн, болгоогтун, тэрвээр үхлийг амсах тэр өдөр нар мөн түүнчлэн сар болон олол харанхуйлагдаж мөн гэрлээ та нарт өгөхөөс татгалзана; мөн энэ нутгийн гадаргуу дээр, бүр тэрээр үхлийг амсах тэр үеэс, гурван хоногийн турш, нас барагсдын дундаас түүний босох тэр цагийг хүртэл гэрэл байхгүй байх болно.
- 21 Тийм ээ, тэрбээр сүнсээ чөлөөлөх тэр үед олон цагийн турш аянга мөн цахилгаан цахиж, мөн газар доргиж мөн чичрэх болно; мөн энэ газрын гадаргуу дээрх хад чулуу, газар дээр ч мөн доор ч аль аль нь, та нарын одоо цул, эсвээс цул биеийн нэг хэсэг хэмээн мэдэх тэдгээр нь хагарч бутрах болно;
- 22 Тийм ээ, тэдгээр нь хуваагдан цуурч, мөн үүнээс хойш хагархай мөн цуурхай байх болно, мөн бүхэл газрын гадаргуу дээр хагарсан хэлтэрхийнүүд, тийм ээ, газрын дээр мөн доор аль алинд нь байх болно.
- 23 Мөн болгоогтун, аймшигт догшин шуурга болно, мөн олон уулс хөндий болтлоо нурсан байна, мөн одоо хөндий гэж нэрлэгдэж байгаа ч агуу өндөр уулс болох олон газар байх болно.
- 24 Мөн олон дардан зам эвдэрсэн байна, мөн олон хот эзгүй болсон байх болно.
- 25 Мөн олон булш нээгдэж, мөн тэдгээр нь үхэгсдийнхээ олныг нь чөлөөлөх болно; мөн олон гэгээн-тэн олонд үзэгдэх болно.
- 26 Мөн болгоогтун, тэнгэр элч надад тийн ярьсан билээ; учир нь олон цагийн турш аянга мөн цахилгаан цахих болно хэмээн тэрээр надад хэлсэн.

Yea, and it bringeth to pass the condition of repentance, that whosoever repenteth the same is not hewn down and cast into the fire; but whosoever repenteth not is hewn down and cast into the fire; and there cometh upon them again a spiritual death, yea, a second death, for they are cut off again as to things pertaining to righteousness.

Therefore repent ye, repent ye, lest by knowing these things and not doing them ye shall suffer yourselves to come under condemnation, and ye are brought down unto this second death.

But behold, as I said unto you concerning another sign, a sign of his death, behold, in that day that he shall suffer death the sun shall be darkened and refuse to give his light unto you; and also the moon and the stars; and there shall be no light upon the face of this land, even from the time that he shall suffer death, for the space of three days, to the time that he shall rise again from the dead.

Yea, at the time that he shall yield up the ghost there shall be thunderings and lightnings for the space of many hours, and the earth shall shake and tremble; and the rocks which are upon the face of this earth, which are both above the earth and beneath, which ye know at this time are solid, or the more part of it is one solid mass, shall be broken up;

Yea, they shall be rent in twain, and shall ever after be found in seams and in cracks, and in broken fragments upon the face of the whole earth, yea, both above the earth and beneath.

And behold, there shall be great tempests, and there shall be many mountains laid low, like unto a valley, and there shall be many places which are now called valleys which shall become mountains, whose height is great.

And many highways shall be broken up, and many cities shall become desolate.

And many graves shall be opened, and shall yield up many of their dead; and many saints shall appear unto many.

And behold, thus hath the angel spoken unto me; for he said unto me that there should be thunderings and lightnings for the space of many hours.



27 Мөн аянга болон цахилгаан, мөн догшин шуурга үргэлжилж байх үед, эдгээр зүйл байх болно, мөн бүхэл газрын гадаргууг гурав хоногийн турш харанхуй бүрхэх болно хэмээн тэрээр надад хэлсэн бөлгөө.

28 Мөн эдгээр тэмдгүүд мөн эдгээр гайхамшгууд энэ нутгийн бүх гадаргуу дээр улиран тохиох болно гэдэгт тэд итгэж болох зорилгын тулд, хүмүүний үрсийн дунд итгэлгүйн ямар ч шалтгааныг байлгахгүй хэмээх зорилгын тулд олон нь эдгээрээс илүү агуу зүйлсийг харна, хэмээн тэнгэр элч надад хэлэв—

29 Мөн энэ нь, итгэх хэн боловч аврагдаж болно, мөн итгэхгүй хэн боловч, зөв шударгын шударга шүүлт тэдний дээр ирж болох зорилгын тулд болой; мөн түүнчлэн хэрэв тэд буруушаагдвал тэд өөрсдийн дээр буруушаалтыг авчрах бөлгөө.

30 Мөн эдүгээ санагтун, санагтун, ах дүүс минь, мөхөх хэн боловч, өөртөө мөхөх буюу; мөн алдсыг үйлдэх хэн боловч, үүнийг өөртөө үйлдэх буюу; учир нь болгоогтун, та нар чөлөөтэй; өөрсдийнхөө төлөө үйлдэх нь та нарт зөвшөөрөгдсөн билээ; учир нь болгоогтун, Бурхан та нарт мэдлэг өгч мөн тэрээр та нарыг чөлөөтэй болгосон буюу.

31 Та нар хилэнцээс сайныг мэдэж болохын тулд тэрээр та нарт өгсөн, мөн та нар амьдрал эсвэл үхлийг сонгож болохын тулд тэрээр та нарт өгсөн билээ; мөн та нар сайныг хийж мөн сайн болох түүнд сэргээгдэж, өөрөөр хэлбэл сайн болох тэр нь та нарт сэргээгдэж болох бөлгөө; эсвээс та нар хилэнцийг хийж, мөн хилэнцэт болох тэр нь та нарт сэргээгдэж болох бөлгөө.

And he said unto me that while the thunder and the lightning lasted, and the tempest, that these things should be, and that darkness should cover the face of the whole earth for the space of three days.

And the angel said unto me that many shall see greater things than these, to the intent that they might believe that these signs and these wonders should come to pass upon all the face of this land, to the intent that there should be no cause for unbelief among the children of men—

And this to the intent that whosoever will believe might be saved, and that whosoever will not believe, a righteous judgment might come upon them; and also if they are condemned they bring upon themselves their own condemnation.

And now remember, remember, my brethren, that whosoever perisheth, perisheth unto himself; and whosoever doeth iniquity, doeth it unto himself; for behold, ye are free; ye are permitted to act for yourselves; for behold, God hath given unto you a knowledge and he hath made you free.

He hath given unto you that ye might know good from evil, and he hath given unto you that ye might choose life or death; and ye can do good and be restored unto that which is good, or have that which is good restored unto you; or ye can do evil, and have that which is evil restored unto you.

## Хиламан 15

- 1 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, болгоогтун, та нар наманчлахгүй аваас гэр орон чинь хоосрон орхигдох болно гэдгийг би та нарт тунхаглана.
- 2 Тийм ээ, та нар наманчлахгүй аваас, эмэгтэйчүүд чинь хөхүүлж байх өдрөө гашуудах агуу шалтгаантай байх болно; учир нь зугтахаар завдахад мөн орогнох газар та нарт үгүй байх болно; тийм ээ, мөн хүүхдээ тээсэн тэдэнд халаг байна, учир нь тэд хөл хүнд мөн зугтаж чадахгүй байх болно; тиймийн тул, тэд доор дэвслэгдэж мөн мөхөхөөр орхигдох болно.
- 3 Тийм ээ, тэдэнд үзүүлэгдэх эдгээр бүх тэмдгүүд мөн гайхамшгуудыг тэд харна, тэд наманчлахгүй аваас Нифайн хүмүүс гэж нэрлэгдсэн энэ хүмүүст халаг; учир нь болгоогтун, тэд Их Эзэнээр сонгогдсон нэгэн ард түмэн байсаар буй; тийм ээ, Нифайн хүмүүсийг тэр хайрласан, мөн түүнчлэн тэднийг цээрлүүлсэн; тийм ээ, тэр тэднийг хайрладаг учраас алдсуудынх нь өдрүүдэд тэднийг цээрлүүлсэн билээ.
- 4 Гэвч болгоогтун ах дүүс минь, үйлүүд нь үргэлжийн хилэнцэт байсан учир тэрээр леменчүүдийг үзэн ядав, мөн энэ нь тэдний эцэг өвгөдийнх нь уламжлалын алдсын учир билээ. Гэвч болгоогтун, нифайчуудын номлолоор аврал тэдэнд ирсэн бөлгөө; мөн энэ зорилгын тулд Их Эзэн тэдний өдрүүдийг уртасгасан болой.
- 5 Мөн тэдний ихэнх хэсэг нь үүргийнхээ замд байж, мөн тэд Бурханы өмнө хянамгай алхаж, мөн тэд Мосегийн хуулийн дагуу түүний зарлигуудыг мөн түүний дүрмүүд хийгээд тогтоолуудыг дагахаар чармайна гэдгийг та нар болгоогоосой хэмээнэ би.
- 6 Тийм ээ, би та нарт хэлнэ, тэдний ихэнх хэсэг нь үүнийг хийж, мөн тэд ах дүүсийнхээ үлдсэнийг нь үнэний мэдлэгт авчирч болохын тулд тэд шантралгүй хичээнгүйлэн оролдож байна; тиймийн тул өдөр тутам тэдний тоог нэмж байгаа нь олон байна.

## Helaman 15

And now, my beloved brethren, behold, I declare unto you that except ye shall repent your houses shall be left unto you desolate.

Yea, except ye repent, your women shall have great cause to mourn in the day that they shall give suck; for ye shall attempt to flee and there shall be no place for refuge; yea, and wo unto them which are with child, for they shall be heavy and cannot flee; therefore, they shall be trodden down and shall be left to perish.

Yea, wo unto this people who are called the people of Nephi except they shall repent, when they shall see all these signs and wonders which shall be showed unto them; for behold, they have been a chosen people of the Lord; yea, the people of Nephi hath he loved, and also hath he chastened them; yea, in the days of their iniquities hath he chastened them because he loveth them.

But behold my brethren, the Lamanites hath he hated because their deeds have been evil continually, and this because of the iniquity of the tradition of their fathers. But behold, salvation hath come unto them through the preaching of the Nephites; and for this intent hath the Lord prolonged their days.

And I would that ye should behold that the more part of them are in the path of their duty, and they do walk circumspectly before God, and they do observe to keep his commandments and his statutes and his judgments according to the law of Moses.

Yea, I say unto you, that the more part of them are doing this, and they are striving with unwearied diligence that they may bring the remainder of their brethren to the knowledge of the truth; therefore there are many who do add to their numbers daily.

7 Мөн болгоогтун, та нар өөрсдөө мэднэ, учир нь та нар үүнийг гэрчилсэн, үнэний мэдлэгт мөн эцэг өвгөдийнхөө ёс бус мөн жигшүүрт уламжлалын тухай мэдэхээр авчрагдсан болгон нь, мөн тэдэнд зүрх сэтгэлийн өөрчлөлтийг авчрах тэрхүү итгэл хийгээд наманчлал болох Их Эзэнд итгэх итгэлд мөн наманчлал тийш удирдах ариун судруудад, тийм ээ, ариун бошиглогчдын бичсэн бошиглолуудад итгэхээр удирдагдсан болгон нь—

8 Тиймийн тул, үүнд ирсэн болгон нь, сүсэг бишрэлдээ, мөн тэд юугаар чөлөөтэй болгогдсон түүндээчанд гуйвшгүй байгааг та нар өөрсдөө мэднэ.

9 Мөн түүнчлэн тэд дайны зэр зэвсгүүдээ булшилж, мөн тэд ямар нэгэн байдлаар нүгэл үйлдэх болуузай хэмээн тэдгээрийг авахаас та нар айдаг; тийм ээ, тэд нүгэл үлдэхээс айдгийг та нар харж чадна—учир нь болгоогтун дайснаудаараа доор дэвслэгдэхийг мөн алагдахыг тэд өөрсдөө хүлцэх бөлгөө, мөн тэдний эсрэг илднүүдээ өргөхгүй, мөн энэ нь Христэд итгэх тэдний итгэлийн учир бөлгөө.

10 Мөн эдүгээ, тэд итгэдэг тэр зүйлдээ итгэхэд үзүүлэх тэдний тууштай чанарын учир, өөрөөр хэлбэл тэд нэгэнтээ гэгээрсний дараа үзүүлэх гуйвшгүй байдлынхаа учир, болгоогтун, тэдний алдсууд байсан хэдий ч Их Эзэн тэднийг адисалж мөн тэдний өдрүүдийг уртасгах болно—

11 Тийм ээ, бүр тэд итгэлгүйдээ бууран доройтовч, бидний эцэг өвгөдөөр, мөн түүнчлэн бошиглогч Зиносоор, мөн бусад олон бошиглогчоор, ах дүүс леменчүүдийг маань дахин үнэний мэдлэгт хүргэх сэргээлтийн талаар яригдсан цагийг ирэх хүртэл Их Эзэн тэдний өдрүүдийг уртасгах болно.

12 Тийм ээ, би та нарт хэлнэ, Их Эзэний амлалтууд бидний ах дүүст, леменчүүдэд хожмын үед хүргэгдэхээр болсон ажгуу; мөн тэдэнд олон зовлон байх хэдий ч, мөн тэд газрын гадаргуу дээр нааш цааш туугдана, мөн мөрдөгдөж, мөн цохигдон бас хааяагүй тараагдана, мөн хоргодох газаргүй байх хэдий ч, Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй байх болно.

13 Мөн энэ нь Гэтэлгэгчийнх нь мөн тэдний агуу их хийгээд жинхэнэ хоньчны талаарх мэдлэг болох тэрхүү үнэн мэдлэгт тэд дахин авчрагдана, мөн түүний хонин дунд тоологдоно гэсэн бошиглолын дагуу юм.

And behold, ye do know of yourselves, for ye have witnessed it, that as many of them as are brought to the knowledge of the truth, and to know of the wicked and abominable traditions of their fathers, and are led to believe the holy scriptures, yea, the prophecies of the holy prophets, which are written, which leadeth them to faith on the Lord, and unto repentance, which faith and repentance bringeth a change of heart unto them—

Therefore, as many as have come to this, ye know of yourselves are firm and steadfast in the faith, and in the thing wherewith they have been made free.

And ye know also that they have buried their weapons of war, and they fear to take them up lest by any means they should sin; yea, ye can see that they fear to sin—for behold they will suffer themselves that they be trodden down and slain by their enemies, and will not lift their swords against them, and this because of their faith in Christ.

And now, because of their steadfastness when they do believe in that thing which they do believe, for because of their firmness when they are once enlightened, behold, the Lord shall bless them and prolong their days, notwithstanding their iniquity—

Yea, even if they should dwindle in unbelief the Lord shall prolong their days, until the time shall come which hath been spoken of by our fathers, and also by the prophet Zenos, and many other prophets, concerning the restoration of our brethren, the Lamanites, again to the knowledge of the truth—

Yea, I say unto you, that in the latter times the promises of the Lord have been extended to our brethren, the Lamanites; and notwithstanding the many afflictions which they shall have, and notwithstanding they shall be driven to and fro upon the face of the earth, and be hunted, and shall be smitten and scattered abroad, having no place for refuge, the Lord shall be merciful unto them.

And this is according to the prophecy, that they shall again be brought to the true knowledge, which is the knowledge of their Redeemer, and their great and true shepherd, and be numbered among his sheep.

14 Тиймийн тул би та нарт хэлнэ, та нар наманчлахгүй аваас тэдний хувьд энэ нь та нарынхаас илүү дээр байх болно.

15 Учир нь болгоогтун, та нарт үзүүлэгдсэн хүчирхэг ажлууд тэдэнд, тийм ээ, эцэг өвгөдийнхөө уламжлалын учир итгэлгүйдээ бууран доройтсон тэдэнд үзүүлэгдсэн бол, тэд дахин хэзээ ч итгэлгүйдээ бууран доройтохгүйг та нар өөрсдөө үзэх бөлгөө.

16 Тиймийн тул, Их Эзэн хэлдэг: Би тэднийг бүрмөсөн устгахгүй, харин би өөрийн мэргэн ухааны тэрхүү өдөр тэднийг дахин надад эргэж ирэх болгоно хэмээн Их Эзэн хэлдэг.

17 Мөн эдүгээ болгоогтун, нифайчуудын ард түмний талаар Их Эзэн хэлсэн нь: Хэрэв тэд наманчлахгүй, мөн тааллыг минь үйлдэхийг хичээхгүй аваас, тэдний дунд миний үйлдсэн олон хүчирхэг ажил байсан ч итгэлгүйнх нь учир би тэднийг бүрмөсөн устгах болно, хэмээн Их Эзэн хэлдэг; мөн Их Эзэн амьд нь гарцаагүйн адил эдгээр зүйл байх болно хэмээн Их Эзэн хэлдэг бөлгөө.

Therefore I say unto you, it shall be better for them than for you except ye repent.

For behold, had the mighty works been shown unto them which have been shown unto you, yea, unto them who have dwindled in unbelief because of the traditions of their fathers, ye can see of yourselves that they never would again have dwindled in unbelief.

Therefore, saith the Lord: I will not utterly destroy them, but I will cause that in the day of my wisdom they shall return again unto me, saith the Lord.

And now behold, saith the Lord, concerning the people of the Nephites: If they will not repent, and observe to do my will, I will utterly destroy them, saith the Lord, because of their unbelief notwithstanding the many mighty works which I have done among them; and as surely as the Lord liveth shall these things be, saith the Lord.

## Хиламан 16

- 1 Мөн эдүгээ, улиран тохиох дор, хотын хэрмэн дээр ярьсан лемен үндэстэн, Самуелын үгсийг сонссон нь олон байв. Мөн түүний үгэнд итгэсэн болгон одож мөн Нифайг эрэлхийлэв; мөн тэд ирж мөн түүнийг олоод тэд түүнд нүглүүдээ тоочиж мөн үгүйсгэсэнгүй, тэд Их Эзэний төлөө баптисм хүртэхийг хүсэв.
- 2 Гэвч Самуелын үгсэд итгээгүй болгон нь түүнд уурлаж байв; мөн тэд хэрмэн дээрх түүний зүг чулуу шидэж, мөн түүнчлэн олон нь түүнийг хэрмэн дээр зогсож байхад түүний зүг сум харвав; гэвч Их Эзэний Сүнс түүнтэй хамт байв, үүний хэрээр тэд түүнийг чулуунуудаараа бас сумнуудаараа ч онож чадсангүй.
- 3 Эдүгээ тэд түүнийг онож чадахгүйгээ үзээд, түүний үгсэд итгэсэн нь илүү олон байв, үүний хэрээр тэд баптисм хүртэхээр Нифайн зүг одов.
- 4 Учир нь болгоогтун, хүмүүс Христ удахгүй ирэх ёстойг мэдэж болохын тулд Нифай баптисм хүртээж, мөн бошиглож, мөн номлож, наманчил хэмээн тэдэнд хашгирч, тэмдгүүд хийгээд гайхамшгуудыг үзүүлж, хүмүүсийн дунд гайхамшгуудыг үйлдэж байв—
- 5 Тэд итгэж болно гэсэн зорилгын тулд, тэдгээрийн ирэх цагт тэдгээр нь тэдэнд урьдаас мэдүүлэгдсэнийг тэд мэдэж мөн санаж болохын тулд, удахгүй ирэх зүйлүүдийн талаар тэр тэдэнд хэлж байв; тиймийн тул Самуелын үгсэд итгэсэн болгон нь баптисм хүртэхээр түүнд очиж байв, учир нь тэд наманчилж мөн нүглүүдээ хүлээн хүрч ирэв.
- 6 Гэвч тэдний ихэнх хэсэг нь Самуелын үгсэд итгэсэнгүй; тиймийн тул тэд чулуунууд болон сумнуудаараа түүнийг онож чадахгүйгээ үзээд, тэд ахлагчиддаа хашгирч, хэлсэн нь: Энэ хүнийг баривчил, мөн түүнийг хүл, учир нь болгоогтун тэр бол чөтгөр шүглэсэн нэгэн; мөн түүнд орших чөтгөрийн хүчний учир бид түүнийг чулуунууд мөн сумаараа онож чадахгүй; тиймийн тул түүнийг барьж мөн түүнийг хүлж, мөн түүнийг зайлуулагтун.

## Helaman 16

And now, it came to pass that there were many who heard the words of Samuel, the Lamanite, which he spake upon the walls of the city. And as many as believed on his word went forth and sought for Nephi; and when they had come forth and found him they confessed unto him their sins and denied not, desiring that they might be baptized unto the Lord.

But as many as there were who did not believe in the words of Samuel were angry with him; and they cast stones at him upon the wall, and also many shot arrows at him as he stood upon the wall; but the Spirit of the Lord was with him, insomuch that they could not hit him with their stones neither with their arrows.

Now when they saw that they could not hit him, there were many more who did believe on his words, insomuch that they went away unto Nephi to be baptized.

For behold, Nephi was baptizing, and prophesying, and preaching, crying repentance unto the people, showing signs and wonders, working miracles among the people, that they might know that the Christ must shortly come—

Telling them of things which must shortly come, that they might know and remember at the time of their coming that they had been made known unto them beforehand, to the intent that they might believe; therefore as many as believed on the words of Samuel went forth unto him to be baptized, for they came repenting and confessing their sins.

But the more part of them did not believe in the words of Samuel; therefore when they saw that they could not hit him with their stones and their arrows, they cried unto their captains, saying: Take this fellow and bind him, for behold he hath a devil; and because of the power of the devil which is in him we cannot hit him with our stones and our arrows; therefore take him and bind him, and away with him.

7 Мөн тэд түүнд гар хүрэхээр очиход, болгоогтун, тэрээр хэрэмнээс доош үсэрч, мөн тэдний нутгаас гарч, тийм ээ, бүр өөрийн нутагт хүртэл зугтав, мөн өөрийнхөө хүмүүсийн дунд номлож мөн бошиглож эхлэв.

8 Мөн болгоогтун, Нифайчуудын дунд тэрээр хэзээ ч дахин дуулдсангүй; мөн хүмүүсийн хэрэг явдал тийн байв.

9 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын наян зургадугаар он тийн төгсөв.

10 Мөн түүнчлэн шүүгчдийн засаглалын наян долдугаар он тийн төгсөж, уг хүмүүсийн ихэнх хэсэг нь өөрсдийн бардамнал мөн ёс бус байдалдаа үлдэж, мөн багахан хэсэг нь Бурханы өмнө илүү хянамгай алхалж байв.

11 Мөн эдгээр нь түүнчлэн шүүгчдийн засаглалын наян наймдугаар оны нөхцөл байдал байв.

12 Мөн шүүгчдийн засаглалын наян есдүгээр онд уг хүмүүс алдастаа улам илүү хатуурч, мөн Бурханы зарлигуудын эсрэг түүнийг улам улам илүүтэй хийж эхэлснээс бусдаар бол, уг хүмүүсийн хэрэг явдалд зөвхөн ялимгүй өөрчлөлт байв.

13 Гэвч улиран тохиох дор шүүгчдийн засаглалын ердүгээр онд, хүмүүст өгөгдсөн агуу тэмдгүүд мөн гайхамшгууд байв; мөн бошиглогчдын үгс гүйцэлдэж эхлэв.

14 Мөн тэнгэр элчүүд хүмүүнд, мэргэн хүмүүнд үзэгдэж, мөн тэдэнд агуу их баяслын баярт мэдээг тунхаглав; энэ онд судрууд тийн гүйцэлдэж эхлэв.

15 Гэсэн хэдий ч, нифайчууд мөн түүнчлэн леменчүүдийн аль алиных нь хамгийн их итгэлтэй хэсгээс бусад нь бүгд, уг хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж эхлэн, мөн өөрсдийнхөө чадал хийгээд өөрсдийнхөө мэргэн ухаан дээр тулгуурлаж эхлэн, өгүүлсэн нь:

16 Ийм олны дундаас, зарим зүйлийг тэд зөв таасан байж болох юм; гэвч болгоогтун, яригдсан эдгээр агуу их хийгээд гайхамшигт ажлууд бүгд тохион ирэх аргагүйг бид мэднэ.

17 Мөн тэд өөр хоорондоо зөрчилдөж мөн шалтгаглаж эхлэв, өгүүлсэн нь:

And as they went forth to lay their hands on him, behold, he did cast himself down from the wall, and did flee out of their lands, yea, even unto his own country, and began to preach and to prophesy among his own people.

And behold, he was never heard of more among the Nephites; and thus were the affairs of the people.

And thus ended the eighty and sixth year of the reign of the judges over the people of Nephi.

And thus ended also the eighty and seventh year of the reign of the judges, the more part of the people remaining in their pride and wickedness, and the lesser part walking more circumspectly before God.

And these were the conditions also, in the eighty and eighth year of the reign of the judges.

And there was but little alteration in the affairs of the people, save it were the people began to be more hardened in iniquity, and do more and more of that which was contrary to the commandments of God, in the eighty and ninth year of the reign of the judges.

But it came to pass in the ninetieth year of the reign of the judges, there were great signs given unto the people, and wonders; and the words of the prophets began to be fulfilled.

And angels did appear unto men, wise men, and did declare unto them glad tidings of great joy; thus in this year the scriptures began to be fulfilled.

Nevertheless, the people began to harden their hearts, all save it were the most believing part of them, both of the Nephites and also of the Lamanites, and began to depend upon their own strength and upon their own wisdom, saying:

Some things they may have guessed right, among so many; but behold, we know that all these great and marvelous works cannot come to pass, of which has been spoken.

And they began to reason and to contend among themselves, saying:

18 Христ мэтийн тиймэрхүү хүмүүн бие ирнэ гэдэг нь байж болмоор юм биш; хэрэв тийм аваас, мөн тэрээр яригдсанчлан Бурханы Хүү, тэнгэр болон газрын Эцэг юм бол, тэрээр Иерусалимд байх тэдэнд үзүүлснийхээ нэгэн адилаар бидэнд өөрийгөө яагаад үзүүлэхгүй байх билээ

19 Тийм ээ, тэрээр Иерусалимын нутгийн адилаар энэ нутагт ч өөрийгөө яагаад үзүүлэхгүй байх билээ

20 Гэвч болгоогтун, бидний дунд бус, харин алс холд байх нутагт, бидний мэдэхгүй тэр нутагт улиран тохиох ямар нэгэн агуу хийгээд гайхамшигт зүйлд биднийг итгүүлэхээр бидний эцэг өвгөдөөр доош бидэнд гардуулагдсан нь ёс бус уламжлал гэдгийг бид мэднэ; тиймийн тул тэд биднийг харанхуй бүдүүлэг байдалд байлгаж чадна, учир нь бид өөрсдийн нүдээр тэдгээр нь үнэн гэдгийг харах аргагүй бөлгөө.

21 Мөн уг хилэнцэт нэгний башир мөн нууц аргаар, үгсийнх нь зарц, мөн түүнчлэн өөрсдийнх нь зарц байлгах бид ойлгох аргагүй ямар нэгэн агуу нууцыг үйлдэх болно, учир нь үгийг заалгахаар бид тэдгээрийн дээр тулгуурладаг; мөн хэрэв бид тэдэнд өөрсдийгөө мэдүүлбэл, амьдралын маань бүхий л өдрүүдэд тийн тэд биднийг харанхуй бүдүүлэг байдалд байлгах болно.

22 Мөн мунхаг болоод хоосон, өөр олон зүйлийг хүмүүс зүрх сэтгэлдээ төсөөлсөн ажгуу; мөн тэд ихэд сандаагдсан байв, учир нь Сатан алдсыг үйлдүүлэхээр тэднийг үргэлж өдөөн хатгаж байв; тийм ээ, тэрээр уг хүмүүсийн зүрх сэтгэлийг сайны эсрэг мөн ирэх зүйлийн эсрэг хатууруулж болохын тулд, тэрээр уг нутгийн гадаргуу дээр цуурхал болоод зөрчилдөөнүүдийг тарааж явав.

23 Мөн Их Эзэний хүмүүсийн дунд хийгдсэн тэмдгүүд болон гайхамшгууд, мөн тэдний үйлдсэн олон гайхамшигт зүйл байсан хэдий ч, Сатан уг нутгийн бүх гадаргуу дээрх хүмүүсийн зүрх сэтгэлд агуу барьц олжээ.

24 Мөн Нифайн хүмүүсийн дээрх шүүгчдийн засаглалын ердүгээр он тийн төгсөв.

25 Мөн Хиламан болон түүний хөвгүүдийн цэдгийн дагуу, Хиламаны ном ийн төгсөв.

That it is not reasonable that such a being as a Christ shall come; if so, and he be the Son of God, the Father of heaven and of earth, as it has been spoken, why will he not show himself unto us as well as unto them who shall be at Jerusalem?

Yea, why will he not show himself in this land as well as in the land of Jerusalem?

But behold, we know that this is a wicked tradition, which has been handed down unto us by our fathers, to cause us that we should believe in some great and marvelous thing which should come to pass, but not among us, but in a land which is far distant, a land which we know not; therefore they can keep us in ignorance, for we cannot witness with our own eyes that they are true.

And they will, by the cunning and the mysterious arts of the evil one, work some great mystery which we cannot understand, which will keep us down to be servants to their words, and also servants unto them, for we depend upon them to teach us the word; and thus will they keep us in ignorance if we will yield ourselves unto them, all the days of our lives.

And many more things did the people imagine up in their hearts, which were foolish and vain; and they were much disturbed, for Satan did stir them up to do iniquity continually; yea, he did go about spreading rumors and contentions upon all the face of the land, that he might harden the hearts of the people against that which was good and against that which should come.

And notwithstanding the signs and the wonders which were wrought among the people of the Lord, and the many miracles which they did, Satan did get great hold upon the hearts of the people upon all the face of the land.

And thus ended the ninetieth year of the reign of the judges over the people of Nephi.

And thus ended the book of Helaman, according to the record of Helaman and his sons.

# ГУРАВДУГААР НИФАЙ НИФАЙН НОМ ХИЛАМАНЫ ХӨВГҮҮН АСАН ТЭР НИФАЙН ХҮҮ

*Мөн Хиламан нь Иудейн хаан, Зедикаягийн хаанчлалын эхний жил Иерусалимаас гарч ирсэн Лихайн хүү болох Нифайн үр удам асан сайхь Алмагийн хүү асан тэрхүү Алмагийн хөвгүүн болох Хиламаны хөвгүүн билээ.*

## 3 Нифай 1

- 1 ЭДҮГЭЭ улиран тохиох дор ерэн нэгдүгээр он улирч одон мөн Лихай Иерусалимыг орхисон цагаас зургаан зуун жил боллоо; мөн энэ нь уг нутгийн дээр Лаконеус ерөнхий шүүгч бөгөөд захирагч байсан тэр жил байв.
- 2 Мөн Хиламаны хүү, Нифай Зарахемла нутгаас гарч явсан байв, гуулин ялтсууд, мөн хөтлөгдсөн тэр бүх цэдгүүд, мөн Лихай Иерусалимаас гарч одсон цагаас хойш нандигнан хадгалагдсаар буй тэдгээр бүх зүйлүүдийн талаарх хариуцлагыг өөрийн ахмад хөвгүүн асан, хүү Нифайдаа өгөв.
- 3 Тэгээд тэр уг нутгаас гарч явав, мөн тэр хааш явсныг хэн ч үл мэднэ; мөн түүний оронд хүү Нифай нь цэдгүүдийг, тийм ээ, энэ хүмүүсийн цэдгийг хөтлөв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор ерэн хоёрдугаар оны эхэнд, болгоогтун, бошиглогчдын бошиглолууд илүү ихээр гүйцэлдэж эхлэв; учир нь илүү агуу дохионууд мөн илүү агуу гайхамшигт зүйлүүд уг хүмүүсийн дунд хийгдэж эхлэв.
- 5 Гэвч лемен үндэстэн Самуелаар яригдсан үгс гүйцэлдэх цаг нь өнгөрсөн хэмээн хэлж эхэлсэн зарим хүмүүс байв.
- 6 Мөн тэд ах дүүсээ хараад бах нь ханаж эхлэн, хэлсэн нь: Болгоогтун тэр цаг өнгөрсөн, мөн Самуелын үгс гүйцэлдсэнгүй; тиймийн тул, энэ зүйлийн талаарх та нарын баясал болоод та нарын итгэл хоосон байжээ.

## Third Nephi

### The Book of Nephi

#### the Son of Nephi, Who Was the Son of Helaman

*And Helaman was the son of Helaman, who was the son of Alma, who was the son of Alma, being a descendant of Nephi who was the son of Lehi, who came out of Jerusalem in the first year of the reign of Zedekiah, the king of Judah.*

## 3 Nephi 1

Now it came to pass that the ninety and first year had passed away and it was six hundred years from the time that Lehi left Jerusalem; and it was in the year that Lachoneus was the chief judge and the governor over the land.

And Nephi, the son of Helaman, had departed out of the land of Zarahemla, giving charge unto his son Nephi, who was his eldest son, concerning the plates of brass, and all the records which had been kept, and all those things which had been kept sacred from the departure of Lehi out of Jerusalem.

Then he departed out of the land, and whither he went, no man knoweth; and his son Nephi did keep the records in his stead, yea, the record of this people.

And it came to pass that in the commencement of the ninety and second year, behold, the prophecies of the prophets began to be fulfilled more fully; for there began to be greater signs and greater miracles wrought among the people.

But there were some who began to say that the time was past for the words to be fulfilled, which were spoken by Samuel, the Lamanite.

And they began to rejoice over their brethren, saying: Behold the time is past, and the words of Samuel are not fulfilled; therefore, your joy and your faith concerning this thing hath been vain.



- 7 Мөнхүү улиран тохиох дор тэд уг нутаг даяар агуу самуун дэгдээв; мөн итгэсэн хүмүүс ихэд уйтгарлан гуньж эхлэв, яригдсан тэдгээр зүйлүүд ямар нэгэн байдлаар улиран тохиохгүй байхвий хэмээснээс бөлгөө.
- 8 Гэвч болгоогтун, тэдний итгэл хоосон бишийг тэд мэдэж болохын тулд шөнө үгүй байсан мэт нэг өдөр лугаа адил байх тэрхүү өдөр мөн тэрхүү шөнө мөн тэрхүү өдрийг тэд тууштайгаар ажиглан хүлээж байлаа.
- 9 Эдүгээ улиран тохиох дор, бошиглогч Самуелаар өгөгдсөн тэмдэг улиран тохиохгүй бол тэдгээр уламжлалуудад итгэсэн тэд бүгд үхэлд хүргэгдэх өдөр үл итгэгчдээр товлогдов.
- 10 Эдүгээ улиран тохиох дор Нифайн хүү Нифай өөрийн хүмүүсийн энэ ёс бус байдлыг үзээд, сэтгэл зүрх нь үлэмж харамсав.
- 11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр гарч мөн өөрөө газарт бөхийн, мөн өөрийн хүмүүсийн, тийм ээ, эцэг өвгөдийнхөө уламжлалд итгэсний учир устгагдах гэж буй тэдний тусын тулд Бурхандаа хүчтэйгээр залбиран гуйв.
- 12 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэрхүү өдрийн туршид Их Эзэнд хүчтэйгээр залбиран гуйв; мөн болгоогтун, Их Эзэний дуу хоолой түүнд ирж, хэлсэн нь:
- 13 Тэргүүнээ өргөгтүн мөн урамтай байгтун; учрыг болгоогтун, цаг нь ойртлоо, мөн энэ шөнө тэмдэг өгөгдөх болно, мөн ариун бошиглогчдынхоо амаар өөрийн яриулсан бүгдийг би гүйцэлдүүлэх болно гэдгийг дэлхийд үзүүлэхээр маргааш бибээр дэлхийд ирэх болно.
- 14 Болгоогтун, дэлхийн үүслээс хүмүүний үрсэд миний мэдүүлсэн тэр бүх зүйлийг гүйцэлдүүлэхээр, мөн Эцэгийн мөн Хүүгийн—миний учир Эцэгийн, мөн бие махбодийн минь учир Хүүгийн аль алиных нь тааллыг үйлдэхээр би өөрийнхөндөө ирнэ. Мөн болгоогтун, цаг нь ойртлоо, мөн энэ шөнө тэмдэг өгөгдөх болно.

And it came to pass that they did make a great uproar throughout the land; and the people who believed began to be very sorrowful, lest by any means those things which had been spoken might not come to pass.

But behold, they did watch steadfastly for that day and that night and that day which should be as one day as if there were no night, that they might know that their faith had not been vain.

Now it came to pass that there was a day set apart by the unbelievers, that all those who believed in those traditions should be put to death except the sign should come to pass, which had been given by Samuel the prophet.

Now it came to pass that when Nephi, the son of Nephi, saw this wickedness of his people, his heart was exceedingly sorrowful.

And it came to pass that he went out and bowed himself down upon the earth, and cried mightily to his God in behalf of his people, yea, those who were about to be destroyed because of their faith in the tradition of their fathers.

And it came to pass that he cried mightily unto the Lord all that day; and behold, the voice of the Lord came unto him, saying:

Lift up your head and be of good cheer; for behold, the time is at hand, and on this night shall the sign be given, and on the morrow come I into the world, to show unto the world that I will fulfil all that which I have caused to be spoken by the mouth of my holy prophets.

Behold, I come unto my own, to fulfil all things which I have made known unto the children of men from the foundation of the world, and to do the will, both of the Father and of the Son—of the Father because of me, and of the Son because of my flesh. And behold, the time is at hand, and this night shall the sign be given.

- 15 Мөнхүү улиран тохиох дор Нифайд ирсэн тэр үгс нь, яригдсаныхаа дагуу гүйцэлдэв; учрыг болгоогтун, нар шингэхэд харанхуй болсонгүй; мөн шөнө болоход харанхуй болсонгүйн учир хүмүүс гайхаш тасарч эхлэв.
- 16 Мөн бошиглогчдын үгсэд итгээгүй байсан нь, газарт унаж мөн үхсэн мэт болцгоосон нь олон байв, учир нь бошиглогчдын үгсэд итгэсэн тэдэнд төлөвлөсөн устгалын агуу төлөвлөгөө бүтэлгүй болсныг тэд мэдсэн ажээ; учир нь өгөгдсөн тэрхүү тэмдэг ирчихсэн байв.
- 17 Мөн Бурханы Хүү удахгүй үзэгдэх ёстойг тэд мэдэж эхлэв; тийм ээ, эцэст нь өрнөдөөс дорнодыг хүртэл, умард нутаг мөн өмнөд нутгийн аль алинд нь бүх газрын гадаргуу дээрх бүх хүмүүс үлэмж их цочирдон гайхсанаас тэд газарт унав.
- 18 Учир нь бошиглогчид эдгээр зүйлийн тухай олон жилийн турш гэрчилж байсныг, мөн өгөгдсөн тэрхүү тэмдэг ирчихсэнийг тэд мэдэв; мөн тэд өөрсдийн алдас мөн итгэлгүйнхээ учир айж эхэлсэн бөлгөө.
- 19 Мөнхүү улиран тохиох дор тэр шөнийн турш харанхуй байсангүй, харин энэ нь үд дунд лугаа адил гэрэлтэй байв. Мөнхүү улиран тохиох дор өглөө нь нар зохих ёсныхоо дагуу, дахин мандсан болой; мөн энэ нь Их Эзэний төрөх өдөр байсныг өгөгдсөн тэмдгийн учир тэд мэдсэн ажгуу.
- 20 Мөнхүү энэ нь, тийм ээ, бүх зүйлүүд, бошиглогчдын үгсийн дагуу, нэг бүрчлэн улиран тохиожээ.
- 21 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн нэгэн шинэ од үгийн дагуу үзэгдэв.
- 22 Мөнхүү улиран тохиох дор энэ үеэс эхлэн, тэд үзсэн тэрхүү тэмдгүүд хийгээд гайхамшгууддаа итгэхгүй байж болно гэсэн зорилготойгоор зүрх сэтгэлийг нь хатууруулахаар худал хуурмагууд, хүмүүсийн дунд Сатанаар илгээгдэж эхлэв; гэвч эдгээр худал хуурмагууд хийгээд заль мэх байсан хэдий ч, хүмүүсийн ихэнх хэсэг нь итгэж, мөн Их Эзэнд хөрвүүлэгдэв.

And it came to pass that the words which came unto Nephi were fulfilled, according as they had been spoken; for behold, at the going down of the sun there was no darkness; and the people began to be astonished because there was no darkness when the night came.

And there were many, who had not believed the words of the prophets, who fell to the earth and became as if they were dead, for they knew that the great plan of destruction which they had laid for those who believed in the words of the prophets had been frustrated; for the sign which had been given was already at hand.

And they began to know that the Son of God must shortly appear; yea, in fine, all the people upon the face of the whole earth from the west to the east, both in the land north and in the land south, were so exceedingly astonished that they fell to the earth.

For they knew that the prophets had testified of these things for many years, and that the sign which had been given was already at hand; and they began to fear because of their iniquity and their unbelief.

And it came to pass that there was no darkness in all that night, but it was as light as though it was mid-day. And it came to pass that the sun did rise in the morning again, according to its proper order; and they knew that it was the day that the Lord should be born, because of the sign which had been given.

And it had come to pass, yea, all things, every whit, according to the words of the prophets.

And it came to pass also that a new star did appear, according to the word.

And it came to pass that from this time forth there began to be lyings sent forth among the people, by Satan, to harden their hearts, to the intent that they might not believe in those signs and wonders which they had seen; but notwithstanding these lyings and deceivings the more part of the people did believe, and were converted unto the Lord.

- 23 Мөнхүү улиран тохиох дор Нифай мөн түүнчлэн бусад олон нь хүмүүсийн дунд одож, наманчлалд хүргэн баптисм хүртээв, үүний улмаас нүглүүдийн агуу ангижрал байв. Мөн уг нутагт хүмүүс дахин тийн амар амгалан байх болов.
- 24 Мөн Мосегийн хуулийг дагах нь цаашид зайлшгүй биш хэмээн судруудаар батлахыг оролдон, номлож эхэлсэн цөөн хэдээс бусдаар бол зөрчилдөөнүүд үгүй байв. Эдүгээ судруудыг ойлгоогүйн учир энэ зүйлийн хувьд тэд алджээ.
- 25 Гэвч улиран тохиох дор тэд удалгүй хөрвүүлэгдэж, мөн тэд байгаа тэр алдаандаа үнэмшүүлэгдэв, учир нь хууль хараахан гүйцэлдээгүй байсан нь, мөн энэ нь нэг бүрчлэн гүйцэлдэх ёстой нь тэдэнд мэдүүлэгдсэн байв; тийм ээ, энэ нь гүйцэлдэх ёстой гэсэн үг тэдэнд ирэв; тийм ээ, энэ нь бүгд гүйцэлдэх хүртэл нэг зураас, эсвээс нэг үсэг ч гээгдэхгүй; тиймийн тул мөнхүү онд тэд өөрсдийнхөө алдааны мэдлэгт авчрагдаж мөн буруугаа хүлээцгээв.
- 26 Мөн бүх ариун бошиглогчдын бошиглолын үгсийн дагуу улиран тохиосон тэмдгүүдийн учир хүмүүст баярт мэдээг авчран, ерэн хоёрдугаар он тийн улиран одов.
- 27 Мөнхүү улиран тохиох дор уулсын дээр оршсон, уг нутагт бужигналдсан, Гадантоны дээрэмчдээс бусдаар бол, ерэн гуравдугаар он ч түүнчлэн амар амгаланд улирч одов; учир нь тэдний бэхлэлтүүд хийгээд нууц байрууд нь хүмүүс тэднийг хүчээр дийлж чадахааргүй тийм бат бөх байв; тиймийн тул тэд олон аллага үйлдэж, мөн хүмүүсийн дунд их хядлага үйлдсэн болой.
- 28 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудаас тэрсэлсэн олон нь тэдэнд зугтан очсон учир ерэн дөрөвдүгээр онд тэд агуу зэрэгт өсөн нэмэгдэж эхлэв, иймээс нутагтаа үлдсэн нифайчуудад их харамсал учруулав.
- 29 Мөн леменчүүдийн дунд ч их харамслын шалтгаан түүнчлэн байв; учир нь болгоогтун, өсөж том болсон мөн нас бие гүйцэж эхэлсэн, тиймээс биеэ даах болсон мөн Гадантоны дээрэмчидтэй нэгдэхээр зорамчууд болох зарим хүмүүсээр, тэдний худал хуурмагаар, мөн тэдний зусар үгсээр зайлуулан удирдагдсан олон хүүхэд тэдэнд байв.

And it came to pass that Nephi went forth among the people, and also many others, baptizing unto repentance, in the which there was a great remission of sins. And thus the people began again to have peace in the land.

And there were no contentions, save it were a few that began to preach, endeavoring to prove by the scriptures that it was no more expedient to observe the law of Moses. Now in this thing they did err, having not understood the scriptures.

But it came to pass that they soon became converted, and were convinced of the error which they were in, for it was made known unto them that the law was not yet fulfilled, and that it must be fulfilled in every whit; yea, the word came unto them that it must be fulfilled; yea, that one jot or tittle should not pass away till it should all be fulfilled; therefore in this same year were they brought to a knowledge of their error and did confess their faults.

And thus the ninety and second year did pass away, bringing glad tidings unto the people because of the signs which did come to pass, according to the words of the prophecy of all the holy prophets.

And it came to pass that the ninety and third year did also pass away in peace, save it were for the Gadianton robbers, who dwelt upon the mountains, who did infest the land; for so strong were their holds and their secret places that the people could not overpower them; therefore they did commit many murders, and did do much slaughter among the people.

And it came to pass that in the ninety and fourth year they began to increase in a great degree, because there were many dissenters of the Nephites who did flee unto them, which did cause much sorrow unto those Nephites who did remain in the land.

And there was also a cause of much sorrow among the Lamanites; for behold, they had many children who did grow up and began to wax strong in years, that they became for themselves, and were led away by some who were Zoramites, by their lyings and their flattering words, to join those Gadianton robbers.

30 Мөн ийн леменчүүд ч түүнчлэн зовж байв, мөн өсвөр үеийнхний ёс бүс байдлын учир итгэл хийгээд зөв шударга байдлын хувьд тэд доройтож эхлэв.

And thus were the Lamanites afflicted also, and began to decrease as to their faith and righteousness, because of the wickedness of the rising generation.

### 3 Нифай 2

- 1 Мөнхүү улиран тохиох дор тийн ерэн тав дахь он түүнчлэн улирч одов, мөн хүмүүс өөрсдийн сонссон тэмдгүүд болоод гайхамшгуудыг мартаж эхлэв, мөн тэнгэрээс ирэх аливаа тэмдэг эсвээс гайхамшигт улам багаар цочирдон гайхах болж эхлэв, үүний хэрээр тэд зүрх сэтгэлдээ хатуу, мөн оюун санаандаа харалган болж эхлэв, мөн тэд сонссон мөн харсан бүхэндээ итгэхгүй болж эхлэв—
- 2 Хүмүүсийн зүрх сэтгэлийг залилан мөн буруу тийш дагуулахын тулд, тэр нь хүмүүнээр мөн чөтгөрийн хүчээр үйлдэгдсэн хэмээн ямар нэгэн хоосон зүйлийг зүрх сэтгэлдээ төсөөлснөөс буюу; мөн хүмүүсийн зүрх сэтгэлийг Сатан дахин тийн эзэмшив, үүний хэрээр тэрбээр тэдний мэлмийг харалган болгож мөн Христийн сургаал бол мунхаг мөн хоосон зүйл гэдэгт тэднийг итгүүлэхээр дагуулав.
- 3 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс ёс бус хийгээд жигшүүрт үйлд хүчирхэг болж эхлэв; мөн тэмдгүүд болон гайхамшгууд цаашид өгөгдөнө гэдэгт тэд итгэсэнгүй; мөн Сатан явж, хүмүүсийн зүрх сэтгэлийг дагуулан, тэднийг уруу татан мөн тэднийг уг нутагт агуу ёс бусыг хийхэд хүргэв.
- 4 Мөн тийн ерэнзургаа дахь; мөн түүнчлэн ерэндолоо дахь; мөн түүнчлэн ерэннайм дахь; мөн түүнчлэн ерэнес дэх он улирч одов;
- 5 Мөн түүнчлэн нифайчуудын ард түмний дээрх хаан асан Мозаягийн өдрүүдээс хойш зуун жил улирч одсон байв.
- 6 Мөн Лихай Иерусалимыг орхисноос хойш зургаан зуун есөн жил улирч одсон байлаа.
- 7 Мөн Христ дэлхийд ирэх болно хэмээн бошиглогчдоор яригдсан тэрхүү тэмдэг өгөгдсөнөөс хойш есөн жил улирч оджээ.
- 8 Эдүгээ нифайчууд тэмдэг өгөгдсөн энэ үеэс, өөрөөр хэлбэл Христийн ирэлтээс цаг хугацаагаа тоолох болжээ; тиймийн тул, есөн жил улирч оджээ.
- 9 Мөн Нифайн эцэг асан, цэдгүүдийг хариуцаж байсан Нифай Зарахемлагийн нутагт эргэж ирсэнгүй, мөн бүх нутагт хаана ч олддохгүй байв.

### 3 Nephi 2

And it came to pass that thus passed away the ninety and fifth year also, and the people began to forget those signs and wonders which they had heard, and began to be less and less astonished at a sign or a wonder from heaven, insomuch that they began to be hard in their hearts, and blind in their minds, and began to disbelieve all which they had heard and seen—

Imagining up some vain thing in their hearts, that it was wrought by men and by the power of the devil, to lead away and deceive the hearts of the people; and thus did Satan get possession of the hearts of the people again, insomuch that he did blind their eyes and lead them away to believe that the doctrine of Christ was a foolish and a vain thing.

And it came to pass that the people began to wax strong in wickedness and abominations; and they did not believe that there should be any more signs or wonders given; and Satan did go about, leading away the hearts of the people, tempting them and causing them that they should do great wickedness in the land.

And thus did pass away the ninety and sixth year; and also the ninety and seventh year; and also the ninety and eighth year; and also the ninety and ninth year;

And also an hundred years had passed away since the days of Mosiah, who was king over the people of the Nephites.

And six hundred and nine years had passed away since Lehi left Jerusalem.

And nine years had passed away from the time when the sign was given, which was spoken of by the prophets, that Christ should come into the world.

Now the Nephites began to reckon their time from this period when the sign was given, or from the coming of Christ; therefore, nine years had passed away.

And Nephi, who was the father of Nephi, who had the charge of the records, did not return to the land of Zarahemla, and could nowhere be found in all the land.

10 Мөнхүү улиран тохиох дор ихээхэн номлол мөн бошиглол тэдний дунд илгээгдсэн хэдий ч хүмүүс ёс бус байдалдаа хэвээр үлдэв; мөн тийн арав дахь он түүнчлэн улирч одов; мөн арван нэг дэх он түүнчлэн алдаст улирч одов.

11 Мөнхүү улиран тохиох дор арван гурав дахь онд бүх нутаг даяар дайнууд мөн зөрчилдөөнүүд байж эхлэв; мөн хүмүүсээс тийм олныг нь хөнөөж, мөн тийм олон хотыг устгаж, мөн уг нутаг даяар тийм их үхэл мөн алаан хядаан тараасны учир бүх хүмүүсийг, нифайчууд мөн леменчүүдийн аль алиныг нь тэдний эсрэг зэр зэвсэг барихаас аргагүй болгосон Гадантоны дээрэмчид тийн маш олон тоотой болсон аж.

12 Тиймийн тул, Их Эзэнд хөрвүүлэгдсэн бүх леменчүүд өөрсдийн ахан дүүс болох нифайчуудтай нэгдэв, мөн өөрсдийн амь нас мөн эмэгтэйчүүд болон хүүхдүүдийнхээ аюулгүй байдлын төлөө, тийм ээ, мөн өөрсдийн эрхийг, мөн өөрсдийн сүмийн хийгээд өөрсдийн сүсэг бишрэлийн онцгой боломж, мөн өөрсдийн эрх чөлөө хийгээд өөрсдийн чөлөөт байдлыг хадгалан хамгаалахаар Гадантоны дээрэмчдийн эсрэг зэвсэг барихаар албадуулагджээ.

13 Мөнхүү улиран тохиох дор энэ арван гурав дахь он улирч одохын өмнө үлэмж ширүүн болсон энэхүү дайны улмаас нифайчууд бүрэн устгалаар заналхийлэгдэв.

14 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудтай нэгдсэн леменчүүд нифайчуудын дунд тоологдов;

15 Мөн тэдний зүхэл тэднээс авагдаж, мөн тэдний арьс нифайчуудынхтай адил цагаан болжээ;

16 Мөн тэдний залуу эрэгтэйчүүд мөн тэдний охид үлэмж царайлаг болж, мөн тэд нифайчуудын дунд тоологдож, мөн нифайчууд хэмээн нэрлэгдэв. Мөн тийн арван гуравдугаар он төгсөв.

17 Мөнхүү улиран тохиох дор арван дөрөв дүгээр оны эхэнд, дээрэмчид мөн Нифайн хүмүүсийн хооронд дайн үргэлжилж мөн үлэмж ширүүн болов; гэсэн хэдий ч, Нифайн хүмүүс дээрэмчдийн дээр зарим давуу талыг олж, үүний хэрээр тэд нутгаасаа тэднийг ухраан ууланд мөн тэдний нууц газрууд тийш хөөв.

And it came to pass that the people did still remain in wickedness, notwithstanding the much preaching and prophesying which was sent among them; and thus passed away the tenth year also; and the eleventh year also passed away in iniquity.

And it came to pass in the thirteenth year there began to be wars and contentions throughout all the land; for the Gadianton robbers had become so numerous, and did slay so many of the people, and did lay waste so many cities, and did spread so much death and carnage throughout the land, that it became expedient that all the people, both the Nephites and the Lamanites, should take up arms against them.

Therefore, all the Lamanites who had become converted unto the Lord did unite with their brethren, the Nephites, and were compelled, for the safety of their lives and their women and their children, to take up arms against those Gadianton robbers, yea, and also to maintain their rights, and the privileges of their church and of their worship, and their freedom and their liberty.

And it came to pass that before this thirteenth year had passed away the Nephites were threatened with utter destruction because of this war, which had become exceedingly sore.

And it came to pass that those Lamanites who had united with the Nephites were numbered among the Nephites;

And their curse was taken from them, and their skin became white like unto the Nephites;

And their young men and their daughters became exceedingly fair, and they were numbered among the Nephites, and were called Nephites. And thus ended the thirteenth year.

And it came to pass in the commencement of the fourteenth year, the war between the robbers and the people of Nephi did continue and did become exceedingly sore; nevertheless, the people of Nephi did gain some advantage of the robbers, insomuch that they did drive them back out of their lands into the mountains and into their secret places.

18 Мөн ийн арван дөрөв дүгээр он төгсөв. Мөн арван тавдугаар онд тэд Нифайн хүмүүсийн эсрэг давшин ирэв; мөн Нифайн хүмүүсийн ёс бусын, мөн тэдний олон зөрчилдөөн мөн тэрслэлүүдийн улмаас, Гадантоны дээрэмчид тэдний дээр олон давуу тал олж авсан ажээ.

19 Мөн ийн арвантав дахь он төгсөж, мөн тийн уг хүмүүс олон зовлон зүдгүүрийн байдалд байв; мөн устгалын илд тэдний дээр далайгдаж, үүний хэрээр тэд түүгээр цохигдох гэж байв, мөн энэ нь тэдний алдсын улмаас буюу.

And thus ended the fourteenth year. And in the fifteenth year they did come forth against the people of Nephi; and because of the wickedness of the people of Nephi, and their many contentions and dissensions, the Gadianton robbers did gain many advantages over them.

And thus ended the fifteenth year, and thus were the people in a state of many afflictions; and the sword of destruction did hang over them, insomuch that they were about to be smitten down by it, and this because of their iniquity.

### 3 Нифай 3

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Христийн ирэлтээс хойш арванзургадугаар онд, уг нутгийн захирагч, Лаконеус, дээрэмчдийн энэ бүлэглэлийн удирдагч бөгөөд захирагчаас захидал хүлээн авав; мөн бичигдсэн тэр үгс нь эдгээр байв, өгүүлсэн нь:
- 2 Тус нутгийн хамгийн эрхэм хүндэт мөн ерөнхий захирагч, Лаконеус, болгоогтун, би энэ захидлыг танд бичиж, мөн өөрсдийн эрх мөн чөлөөт байдал болох үүнийгээ хадгалан хамгаалахад таны гуйвшгүй чанар мөн түүнчлэн таны хүмүүсийн гуйвшгүй чанарын учир танд үлэмж агуу магтаал өргөө; тийм ээ, та нар хэн нэгэн Бурханы мутраар дэмжигдсэн мэтээр чөлөөт байдлаа, мөн хөрөнгөө, бас улс орноо, өөрөөр хэлбэл та нар өөрсдийн тийн нэрлэх тэрнийгээ батлан хамгаалахаар та нар сайн эсэргүүцэн зогсож байна.
- 3 Мөн миний захиргаанд буй—нифайчуудыг дайрч мөн тэднийг устга гэсэн үгийг ихэд тэсч ядан хүлээж байгаа, энэ үед зэвсэгтэйгээ зогсож буй ийм олон зоригт эрсийг та нар сөрөн зогсож чадна хэмээн бодсоноос ийм мунхаг болоод ихэрхүү байгаа нь надад өрөвдмөөр харагдана, эрхэм хүндэт Лаконеус.
- 4 Мөн би, тэднийг тулалдааны талбарт сорьсон учир тэдний тогтоон барихын аргагүй зоригийг мэдэхийн учир, мөн тэдэнд хийсэн та нарын олон буруугийн улмаас та нарын зүг чиглэсэн үүрдийн үзэн ядалтыг нь мэдэхийн учир, тиймийн тул хэрэв тэд та нарын эсрэг ирэх аваас тэд та нарт бүрмөсөн устглаар зочлох болно.
- 5 Тиймийн тул, та нарын зөв хэмээн итгэсэн түүндээ гуйвшгүй чанд, мөн та нарын тулалдааны талбар дахь эр зоригийн учир, та нарын сайн сайхны төлөө зовнисон учир, би энэ захидлыг бичиж, үүнийг өөрийнхөө гараар лацдав.
- 6 Тиймийн тул, тэд та нарт илдтэйгээр зочилж мөн устгал та нарын дээр ирэхийн оронд та нар миний энэ хүмүүст хотуудаа, нутгаа, мөн эзэмшлүүдээ өгтүгэй хэмээн хүсэмжилсний учир би танд бичлээ.

### 3 Nephi 3

And now it came to pass that in the sixteenth year from the coming of Christ, Lachoneus, the governor of the land, received an epistle from the leader and the governor of this band of robbers; and these were the words which were written, saying:

Lachoneus, most noble and chief governor of the land, behold, I write this epistle unto you, and do give unto you exceedingly great praise because of your firmness, and also the firmness of your people, in maintaining that which ye suppose to be your right and liberty; yea, ye do stand well, as if ye were supported by the hand of a god, in the defence of your liberty, and your property, and your country, or that which ye do call so.

And it seemeth a pity unto me, most noble Lachoneus, that ye should be so foolish and vain as to suppose that ye can stand against so many brave men who are at my command, who do now at this time stand in their arms, and do await with great anxiety for the word—Go down upon the Nephites and destroy them.

And I, knowing of their unconquerable spirit, having proved them in the field of battle, and knowing of their everlasting hatred towards you because of the many wrongs which ye have done unto them, therefore if they should come down against you they would visit you with utter destruction.

Therefore I have written this epistle, sealing it with mine own hand, feeling for your welfare, because of your firmness in that which ye believe to be right, and your noble spirit in the field of battle.

Therefore I write unto you, desiring that ye would yield up unto this my people, your cities, your lands, and your possessions, rather than that they should visit you with the sword and that destruction should come upon you.



7 Эсвээс өөрөөр хэлбэл, өөрсдийгөө бидэнд өгч, мөн бидэнтэй нэгдэж мөн бидний нууц ажлуудтай танил болцгоо, мөн та нар бидэнтэй адил байж болохын тулд—бидний боолууд бус, харин бидний ахан дүүс мөн бидний бүх хөрөнгийг хамтран эзэмшигч бидний ах дүүс болцгоо.

8 Мөн болгоогтун, би танд тангараг тавин амлая, хэрэв та нар үүнийг хийвэл, та нар устгагдахгүй, гэвч хэрэв та нар үүнийг хийхгүй бол, би танд тангараг тавин амлая, дараагийн сард ч та нарын эсрэг очихыг Сатанаар зарлиг болгуулна, мөн тэд гараа гатахгүй мөн хэлтрүүлэхгүй, харин та нарыг хөнөөх болно, мөн та нарыг бүр үгүй болох хүртэл илдээ та нар дээр буулгах болно.

9 Мөн болгоогтун, би бол Гидианхай; мөн би бол; энэхүү бүлгийг мөн түүний ажлууд сайн болохыг нь мэддэг Гадиантоны энэхүү нууц бүлэглэлийн захирагч; мөн эдгээр нь эртний үеийнх бөгөөд эдгээр нь бидэнд доош гардуулагдсаар ирсэн бөлгөө.

10 Мөн би энэ захидлыг танд бичиж байна, Лаконеус, мөн та нар нутгаа мөн эзэмшлүүдээ цус урсгалгүйгээр өгнө гэдэгт би найдаж байна, тэдний төр барих эрхүүдийг нь хорьсон та нарын ёс бусын учир та нараас тэрсэлсэн миний энэ хүмүүс өөрсдийн эрхүүд мөн төрөө сэргээж болохын төлөө байгаа билээ, мөн та нар үүнийг хийхгүй бол, би тэдний өшөөг авах болно. Би бол Гидианхай.

11 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Лаконеус энэ захидлыг хүлээн аваад, нифайчуудын нутгийн эзэмшлийг шаардаж, мөн түүнчлэн уг хүмүүсийг заналхийлж мөн тэдгээр ёс бус хийгээд жигшүүрт дээрэмчдэд тэрслэн очиж өөрсдийгөө сүйтгэснээс бусдаар бол, огт сүйтгэгдээгүй тэдний сүйтгэгдсэний өшөөг авах гэсэн Гидианхайн ичгүүр сонжуургүйн учир тэр үлэмж их гайхав.

12 Эдүгээ болгоогтун, энэ Лаконеус, захирагч нь, шударга хүн байж, мөн дээрэмчний шаардлагууд мөн заналхийллүүдээр сүрдүүлэгдсэнгүй; тиймийн тул тэрээр дээрэмчдийн захирагч Гидианхайн захидлыг анхаарсангүй, харин тэрээр өөрийн хүмүүсийг Их Эзэнд хандан, дээрэмчид тэдний эсрэг ирэх цагийн тулд хүч чадлыг гуйхаар болгов.

Or in other words, yield yourselves up unto us, and unite with us and become acquainted with our secret works, and become our brethren that ye may be like unto us—not our slaves, but our brethren and partners of all our substance.

And behold, I swear unto you, if ye will do this, with an oath, ye shall not be destroyed; but if ye will not do this, I swear unto you with an oath, that on the morrow month I will command that my armies shall come down against you, and they shall not stay their hand and shall spare not, but shall slay you, and shall let fall the sword upon you even until ye shall become extinct.

And behold, I am Giddianhi; and I am the governor of this the secret society of Gadianton; which society and the works thereof I know to be good; and they are of ancient date and they have been handed down unto us.

And I write this epistle unto you, Lachoneus, and I hope that ye will deliver up your lands and your possessions, without the shedding of blood, that this my people may recover their rights and government, who have dissented away from you because of your wickedness in retaining from them their rights of government, and except ye do this, I will avenge their wrongs. I am Giddianhi.

And now it came to pass when Lachoneus received this epistle he was exceedingly astonished, because of the boldness of Giddianhi demanding the possession of the land of the Nephites, and also of threatening the people and avenging the wrongs of those that had received no wrong, save it were they had wronged themselves by dissenting away unto those wicked and abominable robbers.

Now behold, this Lachoneus, the governor, was a just man, and could not be frightened by the demands and the threatenings of a robber; therefore he did not hearken to the epistle of Giddianhi, the governor of the robbers, but he did cause that his people should cry unto the Lord for strength against the time that the robbers should come down against them.

13 Тийм ээ, тэд өөрсдийн эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдээ, өөрсдийн бог болон бод малаа, мөн нутгаасаа бусад өөрсдийн бүх хөрөнгийг нэг газарт нэгтгэн цуглуулбал зохино хэмээн тэрээр бүх хүмүүсийн дунд тунхаг бичиг илгээв.

14 Мөн тэрээр өөрсдийн эргэн тойронд бэхлэлтүүд бариулж, мөн тэдгээрийн бат бөх нь үлэмж агуу байхаар болгов. Мөн нифайчуудын хийгээд леменчүүдийн аль алиных нь, өөрөөр хэлбэл нифайчуудын дунд тоологдсон тэд бүгдийн их цэргийг өөрсдийг нь дээрэмчдээс өдөр болон шөнө ч харгалзуулахаар, мөн тэднийг харж хандуулахаар эргэн тойронд нь харуулууд болгон байрлуулав.

15 Тийм ээ, тэрээр тэдэнд хэлэв: Их Эзэн амьдын адил, та нар бүх алдсуудаа наманчилж, мөн Их Эзэнд хандан гуйн залбирахгүй аваас, та нар Гадантоны дээрэмчдийн гараас яавч чөлөөлөгдөхгүй.

16 Мөн Лаконеусын үгс хийгээд бошиглолууд бүх хүмүүсийн дээр айдсыг авчрахаар тийм агуу хийгээд гайхамшигтай байв; мөн тэд Лаконеусын үгсийн дагуу үйлдэхээр бүх хүчээрээ чармайцаав.

17 Мөнхүү улиран тохиох дор, дээрэмчид тэдний эсрэг аглаг буйдаас ирэх тэр цагт тэднийг удирдуулахаар нифайчуудын бүх их цэргийн дээрх ерөнхий ахлагчдыг Лаконеус томилгов.

18 Эдүгээ бүх ерөнхий ахлагчдын ерөнхий нь мөн нифайчуудын бүх цэргийн агуу удирдагч томилогдов, мөн түүний нэр Гидгиддонай байв.

19 Эдүгээ илчлэлтийн мөн түүнчлэн бошиглолын суу билиг бүхий хэн нэгнийг ерөнхий ахлагчаараа томилох нь бүх нифайчуудын дунд заншил байв, (тэдний ёсон бусын үеэс бусад цагт) тиймийн тул, энэхүү Гидгиддонай нь түүнчлэн ерөнхий шүүгчийн адил тэдний дундах агуу бошиглогч байв.

20 Эдүгээ уг хүмүүс Гидгиддонайд хэлэв: Их Эзэнд залбир, мөн бид дээрэмчдийг дайрч мөн тэднийг өөрсдийнх нь газар нутагт устгаж болохын тулд, биднийг ууланд гарч мөн аглаг буйдад одохыг зөвшөөрөөч.

Yea, he sent a proclamation among all the people, that they should gather together their women, and their children, their flocks and their herds, and all their substance, save it were their land, unto one place.

And he caused that fortifications should be built round about them, and the strength thereof should be exceedingly great. And he caused that armies, both of the Nephites and of the Lamanites, or of all them who were numbered among the Nephites, should be placed as guards round about to watch them, and to guard them from the robbers day and night.

Yea, he said unto them: As the Lord liveth, except ye repent of all your iniquities, and cry unto the Lord, ye will in nowise be delivered out of the hands of those Gadianton robbers.

And so great and marvelous were the words and prophecies of Lachoneus that they did cause fear to come upon all the people; and they did exert themselves in their might to do according to the words of Lachoneus.

And it came to pass that Lachoneus did appoint chief captains over all the armies of the Nephites, to command them at the time that the robbers should come down out of the wilderness against them.

Now the chiefest among all the chief captains and the great commander of all the armies of the Nephites was appointed, and his name was Gidgiddoni.

Now it was the custom among all the Nephites to appoint for their chief captains, (save it were in their times of wickedness) some one that had the spirit of revelation and also prophecy; therefore, this Gidgiddoni was a great prophet among them, as also was the chief judge.

Now the people said unto Gidgiddoni: Pray unto the Lord, and let us go up upon the mountains and into the wilderness, that we may fall upon the robbers and destroy them in their own lands.

21 Гэвч Гидгиддонай тэдэнд хэлэв: Их Эзэн хориглож байна; учир нь хэрэв бид тэдний эсрэг өгсөн очвол Их Эзэн биднийг тэдний гарт оруулах болно; тиймийн тул бид өөрсдийгөө нутгийнхаа төвд бэлтгэе, мөн бид бүх их цэргээ нэгтгэн цуглуулъя, мөн бид тэдний эсрэг очихгүй, харин бид тэднийг бидний эсрэг ирэх хүртэл хүлээх болно; тиймийн тул Их Эзэн амьдын адил, хэрэв бид үүнийг хийвэл тэрээр тэднийг бидний гарт оруулах болно.

22 Мөнхүү улиран тохиох дор арван долдугаар онд, уг оны төгсгөлд, Лаконеусын тунхаглал уг нутгийн бүхэл гадаргуу дээр тэр даяар тархсан байв, мөн тэд морьдоо, мөн тэрэгнүүдээ, мөн үхэр малаа, мөн бог, мөн бод малаа, бас үр тариагаа, мөн бүх хөрөнгөө авцгааж, дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө батлан хамгаалахаар нэгдэн цуглах тохиролцсон газартаа тэд бүгд очих хүртлээ мянга мянгаараа мөн хэдэн арван мянгаараа жигдрэн алхаж одов.

23 Мөн тохиролцсон тэр нутаг нь Зарахемлагийн нутаг, мөн Зарахемла нутаг мөн Өгөөмөр нутгийн хоорондох нутаг байв, тийм ээ, Өгөөмөр нутаг мөн Эзгүйрэл нутгийн хоорондох тэр хилийн шугаманд хүртэл байв.

24 Мөн энэ нутагт өөрсдөө нэгдэн цугласан, нифайчууд хэмээн нэрлэгдсэн олон мянган агуу хүмүүс байв. Эдүгээ Лаконеус тэднийг уг нутгийн өмнөд нутагт өөрсдөө нэгдэн цугларах болгов, умард нутгийн дээрх тэр агуу зүхлийн учир бөлгөө.

25 Мөн тэд дайснуудынхаа эсрэг өөрсдийгөө бэхлэв; мөн тэд нэг нутагт, мөн нэг хэсэгт оршиж, мөн тэд Лаконеусаар яригдсан үгсийн төлөө айж, үүний хэрээр тэд бүх нүглүүдээ наманчилсан болой; мөн тэрээр тэднийг дайснууд нь тэдний эсрэг тулалдахаар уруудан ирэх үед чөлөөлөх буйза хэмээн Их Эзэн Бурхандаа тэд залбирлуудаа хандуулж байв.

26 Мөн тэд дайснуудынхаа учир үлэмж харамсаж байв. Мөн Гидгиддонай тэднийг мөн өөрийн удирдамжийн дагуу дайны төрөл бүрийн зэвсгүүд хийхээр, мөн хуяг дуулга, мөн халхавч, бас бамбайтайгаар тэднийг хүчирхэг байхаар болгов.

But Gidgiddoni saith unto them: The Lord forbid; for if we should go up against them the Lord would deliver us into their hands; therefore we will prepare ourselves in the center of our lands, and we will gather all our armies together, and we will not go against them, but we will wait till they shall come against us; therefore as the Lord liveth, if we do this he will deliver them into our hands.

And it came to pass in the seventeenth year, in the latter end of the year, the proclamation of Lachoneus had gone forth throughout all the face of the land, and they had taken their horses, and their chariots, and their cattle, and all their flocks, and their herds, and their grain, and all their substance, and did march forth by thousands and by tens of thousands, until they had all gone forth to the place which had been appointed that they should gather themselves together, to defend themselves against their enemies.

And the land which was appointed was the land of Zarahemla, and the land which was between the land Zarahemla and the land Bountiful, yea, to the line which was between the land Bountiful and the land Desolation.

And there were a great many thousand people who were called Nephites, who did gather themselves together in this land. Now Lachoneus did cause that they should gather themselves together in the land southward, because of the great curse which was upon the land northward.

And they did fortify themselves against their enemies; and they did dwell in one land, and in one body, and they did fear the words which had been spoken by Lachoneus, insomuch that they did repent of all their sins; and they did put up their prayers unto the Lord their God, that he would deliver them in the time that their enemies should come down against them to battle.

And they were exceedingly sorrowful because of their enemies. And Gidgiddoni did cause that they should make weapons of war of every kind, and they should be strong with armor, and with shields, and with bucklers, after the manner of his instruction.

### 3 Нифай 4

- 1 Мөнхүү улиран тохиох дор арван наймдугаар оны төгсгөлд тэдгээр дээрэмчдийн их цэрэг тулалдаанд бэлтгэсэн байв, мөн толгодоос, мөн уулсаас, мөн аглаг буйдаас, мөн өөрсдийн бэхлэлтүүд, мөн нуувч-нуудаасаа гэнэт давшин гарч мөн уруудан ирж эхлэв, мөн уг нутгуудын өмнөд нутагт мөн умард нутагт аль алиныг нь эзэмшилдээ авч эхлэв, мөн нифайчуудаар эзгүйрсэн тэр бүх нутгуудыг, мөн эзгүйрэн орхигдсон хотуудыг эзэмшилдээ авч эхлэв.
- 2 Гэвч болгоогтун, нифайчуудаар эзгүйрүүлэгдсэн нутгуудад зэрлэг араатнууд ч бас ан ч огт байсангүй, аглаг буйдад бус аваас дээрэмчид агнах ан огт үгүй байв.
- 3 Мөн дээрэмчид аглаг буйдад биш аваас амьдарч чадсангүй, учир нь хүнс дутагдаж байв; учир нь нифайчууд нутгуудаа хоосон орхисон байв, мөн өөрсдийн бог мөн бод малаа мөн өөрсдийн бүх хөрөнгөө цуглуулсан байлаа, мөн тэд нэгэн хэсэг байв.
- 4 Тиймийн тул, нифайчуудын эсрэг ил тулалдахаар ирэхгүйгээр, дээрэмчдэд тонох мөн хүнс олж авах ямар ч боломжгүй байв; мөн нифайчууд нэгэн бие байж, мөн маш агуу тоотой байсан учир, мөн өөрсөддөө нөөц хүнс, мөн морьд мөн үхэр мал, бас төрөл бүрийн малыг тэд долоон жилийн турш хүрэлцэхүйцээр хадгалсан байв, тэд дээрэмчдийг тэрхүү хугацааны дотор уг нутгийн гадаргуугаас устгахаар найдаж байв; мөн арван наймдугаар он тийн улирч одов.
- 5 Мөнхүү улиран тохиох дор арван есдүгээр онд Гидианхай нифайчуудын эсрэг тулалдахаар очих нь зайлшгүй байсныг тэрээр олж мэдэв, учир нь тэд тоноул мөн дээрэм мөн аллагаас өөрөөр амьдарч чадахгүй байв.
- 6 Мөн нифайчууд тэдний дээр ирж мөн тэднийг хөнөөх вий хэмээн айснаас тэд үр тариа ургуулахын тулд уг нутгийн гадаргуу дээр тархаж зүрхэлсэнгүй; тиймийн тул Гидианхай энэ онд тэр нифайчуудын эсрэг тулалдахаар очих болно хэмээн их цэрэгтээ зарлиг болов.

### 3 Nephi 4

And it came to pass that in the latter end of the eighteenth year those armies of robbers had prepared for battle, and began to come down and to sally forth from the hills, and out of the mountains, and the wilderness, and their strongholds, and their secret places, and began to take possession of the lands, both which were in the land south and which were in the land north, and began to take possession of all the lands which had been deserted by the Nephites, and the cities which had been left desolate.

But behold, there were no wild beasts nor game in those lands which had been deserted by the Nephites, and there was no game for the robbers save it were in the wilderness.

And the robbers could not exist save it were in the wilderness, for the want of food; for the Nephites had left their lands desolate, and had gathered their flocks and their herds and all their substance, and they were in one body.

Therefore, there was no chance for the robbers to plunder and to obtain food, save it were to come up in open battle against the Nephites; and the Nephites being in one body, and having so great a number, and having reserved for themselves provisions, and horses and cattle, and flocks of every kind, that they might subsist for the space of seven years, in the which time they did hope to destroy the robbers from off the face of the land; and thus the eighteenth year did pass away.

And it came to pass that in the nineteenth year Giddianhi found that it was expedient that he should go up to battle against the Nephites, for there was no way that they could subsist save it were to plunder and rob and murder.

And they durst not spread themselves upon the face of the land insomuch that they could raise grain, lest the Nephites should come upon them and slay them; therefore Giddianhi gave commandment unto his armies that in this year they should go up to battle against the Nephites.

- 7 Мөнхүү улиран тохиох дор тэд тулалдахаар ирэв; мөн энэ нь зургаа дугаар сар байв; мөн болгоогтун, тэдний тулалдахаар ирсэн тэр өдөр агуу хийгээд аймшигтай байв; мөн тэд дээрэмчдийн маягаар хувцасласан байв; мөн хэвлийн тус газраа хурганы арьс бүсэлж, мөн тэд цусанд будагдсан, мөн үсээ нь хусуулсан байж, мөн тэдэнд толгойн хаалт дээр нь байв; мөн хуяг дуулгын учир, мөн тэд цусанд будагдсан учир, Гидианхайн их цэргийн харагдах байдал айдас төрүүлэм хийгээд аймшигтай байлаа.
- 8 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудын их цэрэг, Гидианхайн их цэргийн харагдах байдлыг үзээд, тэд бүгд газарт унаж, мөн Их Эзэн Бурхандаа залбирлаа өргөн, тэрээр дайснуудынх нь гараас тэднийг чөлөөлж мөн тэднийг хэлтрүүлээч хэмээн гуйв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор Гидианхайн их цэрэг үүнийг хараад тэд баяслынхаа учир чанга дуугаар хашгирч эхлэв, учир нь тэдний өөрсдийнх нь их цэргийн аймшигтайн учир нифайчууд айснаас унасан хэмээн бодсон ажээ.
- 10 Гэвч энэ тухайд тэд эндүүрч гутарсан ажгуу, учир нь нифайчууд тэднээс айсан бус; харин тэд Бурханаасаа эмээж, мөн хамгааллын тулд түүнд хандсан болой; тиймийн тул Гидианхайн их цэрэг тэдний дээр довтлон ирэх үед тэдэнтэй тулгарахад тэд бэлтгэгдсэн байв; тийм ээ, Их Эзэний хүч чадлаар тэд тэднийг хүлээн авсан бөлгөө.
- 11 Мөн уг тулалдаан энэ зургадугаар сард эхлэв; мөн тулалдаан агуу хийгээд аймшигтай байв; тийм ээ, түүний хядлага агуу хийгээд аймшигтай байв; үүний хэрээр тэр Иерусалимыг орхисноос хойш Лихайн бүх хүмүүсийн дунд ийм их хядлага хэзээ ч мэдэгдэж байсангүй.
- 12 Мөн Гидианхайн үйлдсэн заналхийллүүд хийгээд тангаргууд байсан хэдий ч, болгоогтун, нифайчууд тэднийг бут цохиж, үүний хэрээр тэд тэдний өмнө гэдрэг ухрав.
- 13 Мөнхүү улиран тохиох дор тэднийг аглаг буйдын хил хязгаарыг хүртэл мөрдөн хөөж, мөн зам зуур тэдний гарт орсон нэгийг ч тэд хэлтрүүлэхгүй байхаар Гидгиддонай их цэрэгтээ зарлиг болгов; мөн тийн тэд аглаг буйдын хязгаар хүртэл, бүр Гидгиддонайн зарлиг гүйцэлдэх хүртэл тэднийг мөрдөж мөн тэднийг хөнөөв.

And it came to pass that they did come up to battle; and it was in the sixth month; and behold, great and terrible was the day that they did come up to battle; and they were girded about after the manner of robbers; and they had a lamb-skin about their loins, and they were dyed in blood, and their heads were shorn, and they had head-plates upon them; and great and terrible was the appearance of the armies of Giddianhi, because of their armor, and because of their being dyed in blood.

And it came to pass that the armies of the Nephites, when they saw the appearance of the army of Giddianhi, had all fallen to the earth, and did lift their cries to the Lord their God, that he would spare them and deliver them out of the hands of their enemies.

And it came to pass that when the armies of Giddianhi saw this they began to shout with a loud voice, because of their joy, for they had supposed that the Nephites had fallen with fear because of the terror of their armies.

But in this thing they were disappointed, for the Nephites did not fear them; but they did fear their God and did supplicate him for protection; therefore, when the armies of Giddianhi did rush upon them they were prepared to meet them; yea, in the strength of the Lord they did receive them.

And the battle commenced in this the sixth month; and great and terrible was the battle thereof, yea, great and terrible was the slaughter thereof, insomuch that there never was known so great a slaughter among all the people of Lehi since he left Jerusalem.

And notwithstanding the threatenings and the oaths which Giddianhi had made, behold, the Nephites did beat them, insomuch that they did fall back from before them.

And it came to pass that Gidgiddoni commanded that his armies should pursue them as far as the borders of the wilderness, and that they should not spare any that should fall into their hands by the way; and thus they did pursue them and did slay them, to the borders of the wilderness, even until they had fulfilled the commandment of Gidgiddoni.

- 14 Мөнхүү улиран тохиох дор зоригтойгоор зогсож мөн тэмцсэн Гидианхай, тэрээр зугтаж байхдаа мөрдөгдөв; мөн их тулааныхаа учир тэрээр сульдсанаас тэр гүйцэгдэж мөн алагдав. Мөн дээрэмчин Гидианхайн төгсгөл ийн байв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудын их цэрэг хамгаалалтын байрандаа дахин буцаж ирсэн болой. Мөнхүү улиран тохиох дор энэ арван есдүгээр он улирч одон, мөн дээрэмчид тулалдахаар дахин ирсэнгүй; бас хорьдугаар онд ч тэд дахин ирсэнгүй.
- 16 Мөн хориннэгдүгээр онд тэд тулалдахаар ирсэнгүй, гэвч тэд Нифайн хүмүүсийн тал бүрээс нь ирж, эргэн тойронд нь бүслэн хаав; учир нь хэрэв тэд Нифайн хүмүүсийг нутгуудаас нь салгаж, мөн тэднийг тал бүрээс нь шахах аваас, мөн хэрэв тэд гаднын бүхий л боломжуудыг нь таслах аваас, тэднийг хүслийнх нь дагуу бууж өгөхөөр болгоно хэмээн тэд бодсон аж.
- 17 Эдүгээ тэд өөрсөддөө өөр нэг удирдагчийг, нэр нь Зимнарайха гэгч түүнийг томилсон байв; тиймийн тул энэхүү бүслэлтийг байрлуулах болгосон нь Зимнарайха байв.
- 18 Гэвч болгоогтун, энэ нь нифайчуудад завшаан болов; учир нь дээрэмчдийн хувьд нифайчуудын дээр ямар нэгэн үр дүн олохуйц хангалттай удаан бүслэн хаах нь, тэдний агуулахад хураасан их хангамжийн учир боломжгүй байв,
- 19 Мөн дээрэмчдийн дундах хангамжуудын ховор хомсын учир; учрыг болгоогтун, тэдний аглаг буйдад олж авсан тэр мах болох, махнаас өөр тэдэнд амь зогоох юу ч байсангүй;
- 20 Мөнхүү улиран тохиох дор уг аглаг буйдад зэрлэг ан нүдний гэм болж, үүний хэрээр дээрэмчид өлсгөлөнгөөр мөхөх нь холгүй байв.
- 21 Мөн нифайчууд өдрөөр ч шөнөөр ч үргэлж гадагш жагсаж, мөн тэдний их цэргийг довтолж, тэднээс мянга мянгаар нь мөн хэдэн арван мянгаар нь хөнөөж байв.
- 22 Мөн, өдрөөр мөн шөнөөр тэдний дээр ирсэн тэр агуу устгалын учир ийн Зимнарайхагийн хүмүүс төлөвлөснөөсөө ухрах хүсэлтэй болов.

And it came to pass that Giddianhi, who had stood and fought with boldness, was pursued as he fled; and being weary because of his much fighting he was overtaken and slain. And thus was the end of Giddianhi the robber.

And it came to pass that the armies of the Nephites did return again to their place of security. And it came to pass that this nineteenth year did pass away, and the robbers did not come again to battle; neither did they come again in the twentieth year.

And in the twenty and first year they did not come up to battle, but they came up on all sides to lay siege round about the people of Nephi; for they did suppose that if they should cut off the people of Nephi from their lands, and should hem them in on every side, and if they should cut them off from all their outward privileges, that they could cause them to yield themselves up according to their wishes.

Now they had appointed unto themselves another leader, whose name was Zemnarihah; therefore it was Zemnarihah that did cause that this siege should take place.

But behold, this was an advantage to the Nephites; for it was impossible for the robbers to lay siege sufficiently long to have any effect upon the Nephites, because of their much provision which they had laid up in store,

And because of the scantiness of provisions among the robbers; for behold, they had nothing save it were meat for their subsistence, which meat they did obtain in the wilderness;

And it came to pass that the wild game became scarce in the wilderness insomuch that the robbers were about to perish with hunger.

And the Nephites were continually marching out by day and by night, and falling upon their armies, and cutting them off by thousands and by tens of thousands.

And thus it became the desire of the people of Zemnarihah to withdraw from their design, because of the great destruction which came upon them by night and by day.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд бүслэлтээс өөрсдөө ухарч, мөн умард нутгийн хамгийн алсын хэсгүүд тийш жагсан одох зарлигийг Зимнарайха өөрийн хүмүүст өгөв.

24 Мөн эдүгээ, Гидгиддонай тэдний төлөвлөснийг мэдэж, мөн хүнс дутагдсаны учир тэдний сульдсаныг, мөн тэдний дунд хийгдсэн агуу хядлагыг мэдэж байснаас, тиймийн тул тэрээр шөнийн цагт их цэргээ илгээж мөн тэдний ухрах замыг хааж, тэдний ухрах зам дээр их цэргээ байрлуулав.

25 Мөн үүнийг тэд шөнө хийсэн аж, мөн дээрэмчдийн цаад талд нь жагсаж хүрэв, иймээс маргааш нь, дээрэмчид жагсан алхаж эхлэхдээ, тэд нифайчуудын их цэргээр урд талаасаа мөн араасаа аль алинаас нь тулгагдсан аж.

26 Мөн өмнөдөд байсан дээрэмчид түүнчлэн ухрах байруудаасаа тусгаарлагдав. Мөн эдгээр бүх зүйл Гидгиддонайн зарлигаар хийгдсэн ажээ.

27 Мөн нифайчуудад өөрсдийгөө хоригдлууд болгон бууж өгсөн олон мянга нь байв, мөн тэдний үлдсэн нь алагдсан бөлгөө.

28 Мөн тэдний удирдагч, Зимнарайха баривчлагдаж тийм ээ, бүр түүний орой дээр үхэх хүртлээ модон дээр дүүжлэгдэв. Мөн тэд түүнийг үхэх хүртэл нь дүүжлээд, тэд уг модыг газарт унагаж, мөн чанга дуугаар хашгирч хэлсэн нь:

29 Их Эзэн өөрийн хүмүүсийг зөв шударга байдалд мөн зүрх сэтгэлийн ариунд байхад нь, тиймээс хүч чадал мөн нууц бүлэглэлүүдийн учир өөрсдийг нь алахыг эрэлхийлэх тэр бүгдийг, тэд газарт унагаагдах болгож болохын тулд, бүр энэ хүн газарт унагаагдсаны адилаар хадгалан хамгаалах болтугай.

30 Мөн тэд баясаж мөн нэгэн дуугаар дахин хашгирч хэлсэн нь: Тэд хамгааллын төлөө Бурханыхаа нэрийг дуудаж байгаа цагт Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурхан, энэ хүмүүсийг зөв шударга байдалд нь хамгаалах болтугай.

31 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд нэгэн зэрэг дуулж эхлэв; мөн дайснуудынхаа гарт орохоос нь тэднийг хамгаалахад, тэдний төлөө түүний хийсэн тэр агуу их зүйлийн төлөө Бурханаа магтан дуулав.

And it came to pass that Zemnarihah did give command unto his people that they should withdraw themselves from the siege, and march into the furthermost parts of the land northward.

And now, Gidgiddoni being aware of their design, and knowing of their weakness because of the want of food, and the great slaughter which had been made among them, therefore he did send out his armies in the night-time, and did cut off the way of their retreat, and did place his armies in the way of their retreat.

And this did they do in the night-time, and got on their march beyond the robbers, so that on the morrow, when the robbers began their march, they were met by the armies of the Nephites both in their front and in their rear.

And the robbers who were on the south were also cut off in their places of retreat. And all these things were done by command of Gidgiddoni.

And there were many thousands who did yield themselves up prisoners unto the Nephites, and the remainder of them were slain.

And their leader, Zemnarihah, was taken and hanged upon a tree, yea, even upon the top thereof until he was dead. And when they had hanged him until he was dead they did fell the tree to the earth, and did cry with a loud voice, saying:

May the Lord preserve his people in righteousness and in holiness of heart, that they may cause to be felled to the earth all who shall seek to slay them because of power and secret combinations, even as this man hath been felled to the earth.

And they did rejoice and cry again with one voice, saying: May the God of Abraham, and the God of Isaac, and the God of Jacob, protect this people in righteousness, so long as they shall call on the name of their God for protection.

And it came to pass that they did break forth, all as one, in singing, and praising their God for the great thing which he had done for them, in preserving them from falling into the hands of their enemies.

32 Тийм ээ, тэд хашгирч: Бүхний Дээд Бурханд  
Хосанна. Мөн тэд хашгирч: Бүхнийг Чадагч Их Эзэн  
Бурхан, Бүхний Дээд Бурханы нэр алдаршиг хэмээв.

33 Мөн тэднийг дайснуудынх нь гараас чөлөөлж буй  
Бурханы агуу сайн сайхны учир их нулимс асгаруу-  
лах хүртлээ, тэдний сэтгэл зүрх баяслаар бялхав; мөн  
тэд үүрдийн устгалаас чөлөөлөгдсөний учир нь тэд-  
ний наманчлал хийгээд тэдний даруу байдал гэдгийг  
тэд мэдсэн бөлгөө.

Yea, they did cry: Hosanna to the Most High God.  
And they did cry: Blessed be the name of the Lord God  
Almighty, the Most High God.

And their hearts were swollen with joy, unto the  
gushing out of many tears, because of the great good-  
ness of God in delivering them out of the hands of their  
enemies; and they knew it was because of their repen-  
tance and their humility that they had been delivered  
from an everlasting destruction.



### 3 Нифай 5

- 1 Мөн эдүгээ болгоогтун, бүх ариун бошиглогчдын ярьсан үгсэд өчүүхэн ч гэсэн эргэлзсэн нэгээхэн ч амьд бодгаль нифайчуудын бүх ард түмний дунд байсангүй; учир нь тэдгээр нь зайлшгүй гүйцэлдэх ёстойг тэд мэдсэн байлаа.
- 2 Мөн бошиглогчдын үгсийн дагуу өгөгдсөн олон тэмдгүүдийн учир, Христ ирсэн нь зайлшгүй байх ёстойг тэд мэдсэн бөлгөө; мөн аль хэдийн улиран тохиосон зүйлүүдийн учир, яригдсан тэрний дагуу бүх зүйл улиран тохиох нь зайлшгүйг тэд мэдэж байв.
- 3 Тиймийн тул тэд бүх нүглүүдээ мөн жигшүүрт хэргүүдээ, мөн садар самуун явдлуудаа орхиж, мөн өдөр болоод шөнө Бурханд байдгаараа хичээнгүйлэн үйлчилж байлаа.
- 4 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор тэд бүх дээрэмчдийг хоригдлууд болгон баривчилж, үүний хэрээр тэднээс алагдаагүй хэн нь ч зугтаж чадсангүй, тэд хоригдлуудаа шоронд хаяж, мөн Бурханы үгийг тэдэнд номлогдохоор болгов; мөн нүглүүдээ наманчилж мөн тэд цаашид аллага үйлдэхгүй гэсэн гэрээнд орсон болгон чөлөөт байдалд суллагдав.
- 5 Харин гэрээнд ороогүй тэр, мөн зүрх сэтгэлдээ тэдгээр нууц аллагуудаа үргэлжлүүлэн агуулсаар л байсан тэр болгон нь, тийм ээ, ах дүүсийнхээ эсрэг заналхийлэл үүсгэж байгаа нь мэдэгдсэн болгон нь хуулийн дагуу яллагдаж мөн шийтгэгдэв.
- 6 Мөн тийм их ёс бус мөн тийм их аллагууд үйлдэгдсэн тэдгээр бүх ёс бус, мөн нууц, мөн жигшүүрт бүлэглэлүүдэд тэд тийн төгсгөлийн цэг тавьсан билээ.
- 7 Мөн хорин хоёр дахь он, мөн түүнчлэн хорин гурав дахь ч, мөн хорин дөрөв, мөн хорин тав дахь ч тийн улирч одов; мөн хорин таван жил тийн улирч одсон байв.
- 8 Мөн зарим хүмүүсийн нүдэнд агуу хийгээд гайхамшигт болох олон зүйл тохиосон байв; гэсэн хэдий ч, тэд бүгд энэ номонд бичигдэх аргагүй; тийм ээ, энэ ном нь уг хорин таван жилийн хугацаанд тийм олон хүмүүсийн дунд хийгдсэний зууны нэгийг нь ч агуулж чадахгүй;

### 3 Nephi 5

And now behold, there was not a living soul among all the people of the Nephites who did doubt in the least the words of all the holy prophets who had spoken; for they knew that it must needs be that they must be fulfilled.

And they knew that it must be expedient that Christ had come, because of the many signs which had been given, according to the words of the prophets; and because of the things which had come to pass already they knew that it must needs be that all things should come to pass according to that which had been spoken.

Therefore they did forsake all their sins, and their abominations, and their whoredoms, and did serve God with all diligence day and night.

And now it came to pass that when they had taken all the robbers prisoners, insomuch that none did escape who were not slain, they did cast their prisoners into prison, and did cause the word of God to be preached unto them; and as many as would repent of their sins and enter into a covenant that they would murder no more were set at liberty.

But as many as there were who did not enter into a covenant, and who did still continue to have those secret murders in their hearts, yea, as many as were found breathing out threatenings against their brethren were condemned and punished according to the law.

And thus they did put an end to all those wicked, and secret, and abominable combinations, in the which there was so much wickedness, and so many murders committed.

And thus had the twenty and second year passed away, and the twenty and third year also, and the twenty and fourth, and the twenty and fifth; and thus had twenty and five years passed away.

And there had many things transpired which, in the eyes of some, would be great and marvelous; nevertheless, they cannot all be written in this book; yea, this book cannot contain even a hundredth part of what was done among so many people in the space of twenty and five years;

- 9 Гэвч болгоогтун энэ хүмүүсийн бүхий л үйлүүдийг агуулдаг цэдгүүд байдаг; мөн илүү богинохон хэдий ч үнэн шастир Нифайгаар өгөгдсөн билээ.
- 10 Тиймийн тул би эдгээр зүйлийн талаарх өөрийн цэдгийг Нифайн ялтсууд гэж нэрлэгдсэн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн Нифайн цэдгийн дагуу хийв.
- 11 Мөн болгоогтун, өөрийнхөө гараар хийсэн ялтсууд дээр би энэхүү цэдгийг хөтөлж байна.
- 12 Мөн болгоогтун, би Мормон гэж нэрлэгдсэн нь, уг хүмүүсийн дунд Алма сүмийг, тийм ээ, тэдний зөрчлийн дараа тэдний дунд байгуулагдсан анхны сүмийг байгуулсан нутаг болох Мормоны нутгийн нэрээр нэрлэгдсэнээс ажээ.
- 13 Болгоогтун, Бурханы Хүү, Есүс Христийн шавь билээ би. Тэд үүрдийн амьдралтай байж болохын тулд түүний үгийг түүний хүмүүсийн дунд тунхаглахаар түүгээр дуудагдсан бөлгөө би.
- 14 Мөн ариун нэгэн асан халин одогсдын залбирлууд итгэлийнх нь дагуу хэрэгжихийн учир, биеллээ олсон эдгээр зүйлийн цэдгийг бичиглэн үлдээх нь Бурханы тааллын дагуу надад зохих зүйл болсон билээ—
- 15 Тийм ээ, Лихай Иерусалимыг орхисон тэр цагаас бүр эдүгээ үеийг хүртэлх цагийг эзэлсэн тэрхүү зүйлүүдийн тухай нэгэн бага цэдэг оршвой.
- 16 Тиймийн тул миний өдрийн эхнийг хүртэл, миний өмнө байсан тэднээр өгөгдсөн шастируудаас би өөрийн цэдгийг үйлддэг билээ;
- 17 Мөн тэгээд би өөрийнхөө нүдээр харсан тэр зүйлүүдийн цэдгийг хийдэг.
- 18 Мөн миний хийдэг цэдэг шударга бөгөөд үнэн цэдэг гэдгийг би мэднэ; гэсэн хэдий ч бидний хэлний дагуу, бид бичих аргагүй олон зүйл буй.
- 19 Мөн эдүгээ би өөрийн тухай үгсээ төгсгөл болгож, мөн надаас өмнө байсан тэр зүйлүүдийн талаарх өөрийн шастирыг бичихээ үргэлжлүүлье.

But behold there are records which do contain all the proceedings of this people; and a shorter but true account was given by Nephi.

Therefore I have made my record of these things according to the record of Nephi, which was engraven on the plates which were called the plates of Nephi.

And behold, I do make the record on plates which I have made with mine own hands.

And behold, I am called Mormon, being called after the land of Mormon, the land in which Alma did establish the church among the people, yea, the first church which was established among them after their transgression.

Behold, I am a disciple of Jesus Christ, the Son of God. I have been called of him to declare his word among his people, that they might have everlasting life.

And it hath become expedient that I, according to the will of God, that the prayers of those who have gone hence, who were the holy ones, should be fulfilled according to their faith, should make a record of these things which have been done—

Yea, a small record of that which hath taken place from the time that Lehi left Jerusalem, even down until the present time.

Therefore I do make my record from the accounts which have been given by those who were before me, until the commencement of my day;

And then I do make a record of the things which I have seen with mine own eyes.

And I know the record which I make to be a just and a true record; nevertheless there are many things which, according to our language, we are not able to write.

And now I make an end of my saying, which is of myself, and proceed to give my account of the things which have been before me.

- 20 Би бол Мормон, мөн Лихайн шууд удам билээ. Тэрбээр эцэг өвгөдийг маань Иерусалимын нутгаас гарган авчирч, (мөн тэр өөрөө болон уг нутгаас түүний авчирсан тэднээс бусад хэн ч үл мэдсэн) мөн тэрбээр надад болон миний хүмүүст бодгалиудын маань авралд хүргэх тийм их мэдлэг өгсөн учир, Бурханаа мөн өөрийн Аврагч Есүс Христийг алдаршуулах шалтгаан надад буй.
- 21 Тэрбээр Иаковын угсааг адисалсан, мөн Иосефын үр удамд нигүүлсэнгүй байсан нь гарцаагүй билээ.
- 22 Мөн Лихайн хүүхдүүд түүний зарлигуудыг дагасны хэрээр тэрээр тэднийг адисалж мөн үгийнхээ дагуу тэднийг дэгжүүлсэн билээ.
- 23 Тийм ээ, тэрбээр Иосефын үр удмын үлдэгдлийг Их Эзэн Бурханых нь мэдлэгт дахин авчрах нь гарцаагүй.
- 24 Мөн Их Эзэн амьд нь гарцаагүйн адил, тэрээр дэлхийн бүх гадаргуу дээгүүр тархан тараагдсан, Иаковын үр удмын бүх үлдэгдлийг дэлхийн дөрвөн зүгээс цуглуулах болно.
- 25 Мөн тэрбээр Иаковын бүх угсаатай гэрээ байгуулсны учир, тиймийн тул Иаковын угсаатай байгуулсан уг гэрээ нь түүний тогтоосон цагт биелэгдэх болно, тиймээс тэдэнтэй байгуулсан түүний тэрхүү гэрээний мэдлэгт Иаковын бүх угсаа сэргээгдэх болно.
- 26 Мөн тэгээд, тэд Есүс Христ, Бурханы Хүү болох Гэтэлгэгчээ мэдэх болно; мөн тэгээд дэлхийн дөрвөн зүгээс өөрсдийн газар нутагт, тэд тараагдсан зүгээсээ цуглуулагдах болно; тийм ээ, Их Эзэн амьдын адилаар энэ нь тэрчлэн байх болно. Амен.

I am Mormon, and a pure descendant of Lehi. I have reason to bless my God and my Savior Jesus Christ, that he brought our fathers out of the land of Jerusalem, (and no one knew it save it were himself and those whom he brought out of that land) and that he hath given me and my people so much knowledge unto the salvation of our souls.

Surely he hath blessed the house of Jacob, and hath been merciful unto the seed of Joseph.

And insomuch as the children of Lehi have kept his commandments he hath blessed them and prospered them according to his word.

Yea, and surely shall he again bring a remnant of the seed of Joseph to the knowledge of the Lord their God.

And as surely as the Lord liveth, will he gather in from the four quarters of the earth all the remnant of the seed of Jacob, who are scattered abroad upon all the face of the earth.

And as he hath covenanted with all the house of Jacob, even so shall the covenant wherewith he hath covenanted with the house of Jacob be fulfilled in his own due time, unto the restoring all the house of Jacob unto the knowledge of the covenant that he hath covenanted with them.

And then shall they know their Redeemer, who is Jesus Christ, the Son of God; and then shall they be gathered in from the four quarters of the earth unto their own lands, from whence they have been dispersed; yea, as the Lord liveth so shall it be. Amen.

### 3 Нифай 6

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор нифайчуудын ард түмэн хорин зургадугаар онд, хүн бүр, гэр бүлтэйгээ, бог болон бод малтайгаа, морьдтойгоо мөн үхэр малтайгаа, тэдэнд харьяалагдах юу боловч тэр бүх зүйлтэйгээ бүгд өөрсдийн газар нутагт буцаж очив.
- 2 Мөнхүү улиран тохиох дор бүх нөөц хүнсээ тэд идэж дуусгаагүй байв; тиймийн тул тэд өөрсдийн хэрэглээгүй тэр бүгдээ, төрөл бүрийн бүх үр тариагаа, мөн алтаа, мөн мөнгөө, мөн бүх үнэт зүйлүүдээ авч, мөн тэд умард мөн өмнөд аль алин дахь өөрсдийн газар нутагт, умард зүгийн нутагт мөн өмнө зүгийн нутагт аль алинд нь мөн эзэмшлүүддээ буцав.
- 3 Мөн уг нутгийн энх амгаланг сахих гэрээнд орсон леменчүүд хэвээр үлдэх хүсэлтэй дээрэмчдэд, тэд өөрсдийн хөдөлмөрөөр амь зуух боломжтой байхын тулд, тэдний тооных нь дагуу газар өгөв; мөн тийн тэд бүх нутагт энх амгаланг тогтоосон ажгуу.
- 4 Мөн тэд дахин дэгжиж мөн агуу болж эхлэв; мөн хорин зургаа болон долдугаар онууд улирч одов, мөн уг нутагт агуу дэг журам байв; мөн тэд тэгш эрх мөн шударга ёсны дагуу хуулиудаа тогтоосон байв.
- 5 Мөн эдүгээ бүх нутагт тэд зөрчилд унахаас бусдаар бол уг хүмүүс үргэлж дэгжихэд нь хориг болох юм юу ч үгүй байв.
- 6 Мөн эдүгээ уг нутагт энэхүү агуу амар амгаланг тогтоосон нь Гидгиддонай, мөн шүүгч Лаконеус болон удирдагчдаар тохоогдсон тэд байв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор олон хот шинээр баригдав, мөн олон хуучин хот засварлагдав.
- 8 Мөн хотоос хотод, мөн нутгаас нутагт, мөн газраас газарт хүргэх их хөлийн олон замууд тавигдаж, мөн олон зам баригдав.
- 9 Мөн хорин наймдугаар он тийн улиран одож, мөн уг хүмүүс үргэлжийн энх амгалан байв.
- 10 Гэвч улиран тохиох дор хорин есдүгээр онд уг хүмүүсийн дунд зарим маргаанууд байж эхлэв; мөн зарим нь үлэмж агуу баялгуудынхаа учир бардамнал хийгээд сагсууралдаа хүртэл хөөрч, тийм ээ, бүр агуу хавчлаганд хүрэв;

### 3 Nephi 6

And now it came to pass that the people of the Nephites did all return to their own lands in the twenty and sixth year, every man, with his family, his flocks and his herds, his horses and his cattle, and all things whatsoever did belong unto them.

And it came to pass that they had not eaten up all their provisions; therefore they did take with them all that they had not devoured, of all their grain of every kind, and their gold, and their silver, and all their precious things, and they did return to their own lands and their possessions, both on the north and on the south, both on the land northward and on the land southward.

And they granted unto those robbers who had entered into a covenant to keep the peace of the land, who were desirous to remain Lamanites, lands, according to their numbers, that they might have, with their labors, wherewith to subsist upon; and thus they did establish peace in all the land.

And they began again to prosper and to wax great; and the twenty and sixth and seventh years passed away, and there was great order in the land; and they had formed their laws according to equity and justice.

And now there was nothing in all the land to hinder the people from prospering continually, except they should fall into transgression.

And now it was Gidgiddoni, and the judge, Lachoneus, and those who had been appointed leaders, who had established this great peace in the land.

And it came to pass that there were many cities built anew, and there were many old cities repaired.

And there were many highways cast up, and many roads made, which led from city to city, and from land to land, and from place to place.

And thus passed away the twenty and eighth year, and the people had continual peace.

But it came to pass in the twenty and ninth year there began to be some disputings among the people; and some were lifted up unto pride and boastings because of their exceedingly great riches, yea, even unto great persecutions;

11 Учир нь уг нутагт олон наймаачин, мөн түүнчлэн олон хуульч, мөн олон албан хаагч байв.

12 Мөн хүмүүс баялгуудынхаа мөн суралцах боломжуудынхаа дагуу давхаргаараа ялгарч эхлэв; тийм ээ, ядуугийнхаа учир зарим нь харанхуй бүдүүлэг байж, мөн бусад зарим нь баялгуудынхаа учир агуу эрдэм мэдлэг хүлээн авсан ажгуу.

13 Зарим нь бардамналдаа хөөрч, мөн бусад зарим нь үлэмж даруу байжээ; бусад зарим нь уцаар мөн хавчлага гадуурхал бас бүх төрлийн эүдгүүрүүдийг хүлээж, мөн хараал зүхлээр буцааж хариулалгүй, харин Бурханы өмнө даруу хийгээд гэмшсэн байхад зарим нь уцаарыг уцаараар хариулж байв.

14 Мөн ийн бүх нутагт агуу тэгш бус байдал бий болж, үүний хэрээр сүм хагарч, үнэн сүсэг бишрэлд хөрвүүлэгдсэн леменчүүдийн дундах цөөн хэдээс бусад нь эхлэв; тийм ээ, үүний хэрээр гучдугаар онд бүх нутагт сүм хагарч эхлэв; мөн тэд үүнээс салж явахгүй байв, учир нь тэд бат мөн шаргуу, мөн гуйвшгүй, бүхий л хичээнгүй байдлаараа Их Эзэний зарлигуудыг дагахад бэлэн байв.

15 Эдүгээ хүмүүсийн энэхүү алдсын шалтгаан ийм байв—хүмүүсийг бүх төрлийн алдсыг үйлдэхэд өдөөн хатгах, мөн тэднийг бардамналд хөөргөх, хүч чадал, мөн эрх мэдэл, мөн баялгууд, мөн дэлхийн хоосон зүйлийг эрэлхийлэхэд уруу татах агуу хүчийг Сатан эзэмджээ.

16 Мөн тийн уг хүмүүсийн зүрх сэтгэлийг төрөл бүрийн алдсыг үйлдэхэд Сатан зайцуулан удирдаж байв; тиймийн тул тэд зөвхөн цөөн хэдэн жил амар амгалан байв.

17 Мөн тийн, гучдугаар оны эхэнд—чөтгөрийн уруу таталтуудаар тэднийг хааш чиглүүлэхийг хүссэн тэр зүгт чиглүүлэх, мөн тэднээс түүний хүссэн юуг боловч алдсыг үйлдэх байдалд хүмүүс удаан хугацааны турш орхигдсон байв—мөн тийн энэхүү гучдугаар оны эхэнд, тэд аймшигт ёс бус байдалд байв.

18 Эдүгээ тэд харанхуй бүдүүлгээр нүгэл үйлдсэнгүй, учир нь өөрсдийн талаарх Бурханы тааллыг тэд мэдсэн байв, учир нь энэ нь тэдэнд заагдсан байлаа; тиймийн тул тэд Бурханы эсрэг санаатайгаар эсэргүүцсэн ажээ.

For there were many merchants in the land, and also many lawyers, and many officers.

And the people began to be distinguished by ranks, according to their riches and their chances for learning; yea, some were ignorant because of their poverty, and others did receive great learning because of their riches.

Some were lifted up in pride, and others were exceedingly humble; some did return railing for railing, while others would receive railing and persecution and all manner of afflictions, and would not turn and revile again, but were humble and penitent before God.

And thus there became a great inequality in all the land, insomuch that the church began to be broken up; yea, insomuch that in the thirtieth year the church was broken up in all the land save it were among a few of the Lamanites who were converted unto the true faith; and they would not depart from it, for they were firm, and steadfast, and immovable, willing with all diligence to keep the commandments of the Lord.

Now the cause of this iniquity of the people was this—Satan had great power, unto the stirring up of the people to do all manner of iniquity, and to the puffing them up with pride, tempting them to seek for power, and authority, and riches, and the vain things of the world.

And thus Satan did lead away the hearts of the people to do all manner of iniquity; therefore they had enjoyed peace but a few years.

And thus, in the commencement of the thirtieth year—the people having been delivered up for the space of a long time to be carried about by the temptations of the devil whithersoever he desired to carry them, and to do whatsoever iniquity he desired they should—and thus in the commencement of this, the thirtieth year, they were in a state of awful wickedness.

Now they did not sin ignorantly, for they knew the will of God concerning them, for it had been taught unto them; therefore they did wilfully rebel against God.

- 19 Мөн эдүгээ энэ нь Лаконеусын хүү Лаконеусын өдрүүд байв, учир нь Лаконеус эцгийнхээ суудлыг эзэлж мөн хүмүүсийг тэр онд захирсан болой.
- 20 Мөн тэнгэрээс бурханлигаар нөлөөлөгдсөн мөн илгээгдсэн хүмүүс байж эхлэв, бүх нутагт хүмүүсийн дунд зогсоод, номлон мөн хүмүүсийн нүглүүд хийгээд алдсуудын тухай зоригтойгоор гэрчилж, мөн Их Эзэн өөрийн хүмүүсийн төлөө хийх гэтэлгэлийн, эсвээс өөрөөр хэлбэл, Христийн амилалтын талаар тэдэнд гэрчилж байв; мөн тэд түүний үхэл хийгээд зовлонгийн тухай зоримгоор гэрчилсэн бөлгөө.
- 21 Эдүгээ эдгээр зүйлийн тухай гэрчилсэн тэдний учир үлэмж ууртай байсан олон хүмүүс байв; мөн ууртай байсан тэд гол төлөв ерөнхий шүүгчид, мөн дээд санваартан, мөн хуульчид асан байв, тийм ээ, хуульчид болох тэд бүгд эдгээр зүйлийг гэрчилсэн тэдэнд уурлаж байв.
- 22 Эдүгээ ямар ч хуульч бас шүүгч бас дээд санваартан уг нутгийн захирагчаар тэдний ял мутарлагдаагүй аваас хэн нэгнийг үхэлд хүргэн яллах хүчтэй байж чадахгүй байв.
- 23 Эдүгээ Христэд хамаарагдах зүйлүүдийн тухай гэрчилсэн тэднийг олон нь зоригтойгоор гэрчилсэн аж, шүүгчдээр нууцаар баривчлагдаж мөн үхэлд хүргэгдсэн учир үхлийнх нь дараа болтол тэдний үхлийн тухай мэдэгдэл уг нутгийн захирагчид очоогүй байв.
- 24 Эдүгээ болгоогтун, уг нутгийн захирагчаас тэд эрх авснаас бусдаар бол хэн нэгнийг үхэлд хүргэх нь уг нутгийн хуулиудын эсрэг байв—
- 25 Тиймийн тул Зарахемлагийн нутагт, уг нутгийн захирагчид, Их Эзэний бошиглогчдыг, хуулийн дагуу бус үхэлд хүргэн ялласан эдгээр шүүгчдийн эсрэг гомдол ирэв.
- 26 Эдүгээ улиран тохиох дор тэд баривчлагдаж мөн уг шүүгчийн өмнө, тэд үйлдсэн гэмт хэрэгтээ, уг хүмүүсээр тогтоогдсон тэрхүү хуулийн дагуу шүүгдэхээр авчрагдав.

And now it was in the days of Lachoneus, the son of Lachoneus, for Lachoneus did fill the seat of his father and did govern the people that year.

And there began to be men inspired from heaven and sent forth, standing among the people in all the land, preaching and testifying boldly of the sins and iniquities of the people, and testifying unto them concerning the redemption which the Lord would make for his people, or in other words, the resurrection of Christ; and they did testify boldly of his death and sufferings.

Now there were many of the people who were exceedingly angry because of those who testified of these things; and those who were angry were chiefly the chief judges, and they who had been high priests and lawyers; yea, all those who were lawyers were angry with those who testified of these things.

Now there was no lawyer nor judge nor high priest that could have power to condemn any one to death save their condemnation was signed by the governor of the land.

Now there were many of those who testified of the things pertaining to Christ who testified boldly, who were taken and put to death secretly by the judges, that the knowledge of their death came not unto the governor of the land until after their death.

Now behold, this was contrary to the laws of the land, that any man should be put to death except they had power from the governor of the land—

Therefore a complaint came up unto the land of Zarahemla, to the governor of the land, against these judges who had condemned the prophets of the Lord unto death, not according to the law.

Now it came to pass that they were taken and brought up before the judge, to be judged of the crime which they had done, according to the law which had been given by the people.

27 Эдүгээ улиран тохиох дор тэдгээр шүүгчдэд олон найз мөн садан төрөл байв; мөн үлдсэн нь, тийм ээ, бүр бараг бүх хуульчид мөн дээд санваартнууд, өөрсдөө нэгдэн цугларч, мөн хуулийн дагуу шалгагдах болсон тэдгээр шүүгчдийн садан төрлийнхөнтэй нэгдэв.

28 Мөн тэд нэг нэгэнтэйгээ гэрээнд оров, тийм ээ, бүр хуучны тэднээр өгөгдсөн гэрээнд, бүх зөв шударгын эсрэг нэгтгэхээр чөтгөрөөр өгөгдсөн мөн удирдагдсан тэрхүү гэрээнд болой.

29 Тиймийн тул Их Эзэний хүмүүсийн эсрэг тэд нэгдэж, мөн тэднийг устгахаар, мөн хуулийн дагуу хэргжүүлэгдэх гэж байсан тэр, шударга ёсны атгалтаас аллагын гэмтэй тэднийг чөлөөлөхөөр гэрээнд оров.

30 Мөн тэд улс орныхоо хуулийг мөн эрхийг үл ойшоов; мөн уг нутаг цаашид эрх чөлөөт бус, харин хааны харьяат байхын тулд захирагчийг устгахаар, мөн уг нутгийн дээр хааныг тогтоохоор тэд нэг нэгэнтэйгээ гэрээ хийв.

Now it came to pass that those judges had many friends and kindreds; and the remainder, yea, even almost all the lawyers and the high priests, did gather themselves together, and unite with the kindreds of those judges who were to be tried according to the law.

And they did enter into a covenant one with another, yea, even into that covenant which was given by them of old, which covenant was given and administered by the devil, to combine against all righteousness.

Therefore they did combine against the people of the Lord, and enter into a covenant to destroy them, and to deliver those who were guilty of murder from the grasp of justice, which was about to be administered according to the law.

And they did set at defiance the law and the rights of their country; and they did covenant one with another to destroy the governor, and to establish a king over the land, that the land should no more be at liberty but should be subject unto kings.

### 3 Нифай 7

- 1 Эдүгээ болгоогтун, тэд уг нутгийн дээр хааныг тогтоогоогүйг би та нарт үзүүлье; харин мөнхүү энэ онд, тийм ээ, гучдугаар он, тэд шүүлтийн суудал дээр нь устгасан, тийм ээ, уг нутгийн ерөнхий шүүгчийг хөнөөн болой.
- 2 Мөн хүмүүс нэг нь нөгөөгийнхөө эсрэг хуваагдав, хүн бүр өөрийн гэр бүл мөн өөрийн садан төрөл хийгээд найз нөхдийнхөө дагуу тэд нэг нь нөгөөгөөсөө овгуудад тусгаарлагдав; мөн тийн тэд уг нутгийн засгийн газрыг устгасан билээ.
- 3 Мөн овог болгон толгойлогч буюу удирдагчаа өөрсдийн дээр тохоосон болой; мөн тийн тэд овгууд мөн овгуудын удирдагчид болцгоов.
- 4 Эдүгээ болгоогтун, тэдний дунд том гэр бүл мөн олон садан төрөл мөн найз нөхөдгүй нэг ч хүн байсангүй; тиймийн тул тэдний овгууд үлэмж агуу болов.
- 5 Эдүгээ энэ бүгд нь хийгдэж, мөн тэдний дунд дайнууд хараахан байсангүй; мөн тэд өөрсдийгөө Сатаны хүчинд өгсөн учир энэ бүх алдас уг хүмүүсийн дээр ирсэн байв.
- 6 Мөн бошиглогчдыг алсан тэдний найзууд мөн төрөл садных нь нууц бүлэглэлийн учир засгийн газрын журам зохицуулалт устгагджээ.
- 7 Мөн тэд уг нутагт агуу зөрчилдөөн үүсгэж, үүний хэрээр хүмүүсийн илүү зөв шударга хэсэг нь бараг бүгд ёс бус болсон байв; тийм ээ, тэдний дунд зөвхөн цөөн хэдэн зөв шударга хүмүүс л байв.
- 8 Мөн бөөлжсөө долоох нохой мэт эсвээс намагт хөлбөрөх гахай мэт, хүмүүсийн ихэнх хэсэг нь зөв шударга байдлаасаа буцсанаас хойш тийн зургаан жил улиран одоогүй байлаа.
- 9 Эдүгээ уг хүмүүсийн дээр ийм агуу алдсыг авчирсан энэ нууц бүлэглэл, өөрсдөө нэгдэн цугларч, мөн тэд Иаков гэж нэрлэсэн тэр хүнийг өөрсдийн тэргүүн болгон байрлуулав;
- 10 Мөн тэд түүнийг хаанаа хэмээн нэрлэв; тиймийн тул тэрээр энэхүү ёс бус холбооны дээр хаан болжээ; мөн Есүсийн тухай гэрчилсэн бошиглогчдын эсрэг ярьсан сайхь голлох хэдийн нэг нь тэр байв.

### 3 Nephi 7

Now behold, I will show unto you that they did not establish a king over the land; but in this same year, yea, the thirtieth year, they did destroy upon the judgment-seat, yea, did murder the chief judge of the land.

And the people were divided one against another; and they did separate one from another into tribes, every man according to his family and his kindred and friends; and thus they did destroy the government of the land.

And every tribe did appoint a chief or a leader over them; and thus they became tribes and leaders of tribes.

Now behold, there was no man among them save he had much family and many kindreds and friends; therefore their tribes became exceedingly great.

Now all this was done, and there were no wars as yet among them; and all this iniquity had come upon the people because they did yield themselves unto the power of Satan.

And the regulations of the government were destroyed, because of the secret combination of the friends and kindreds of those who murdered the prophets.

And they did cause a great contention in the land, in-somuch that the more righteous part of the people had nearly all become wicked; yea, there were but few righteous men among them.

And thus six years had not passed away since the more part of the people had turned from their righteousness, like the dog to his vomit, or like the sow to her wallowing in the mire.

Now this secret combination, which had brought so great iniquity upon the people, did gather themselves together, and did place at their head a man whom they did call Jacob;

And they did call him their king; therefore he became a king over this wicked band; and he was one of the chiefest who had given his voice against the prophets who testified of Jesus.



11 Мөнхүү улиран тохиох дор, хүн бүр өөрийн овгийн дагуу тэдний удирдагчид өөрсдийн хуулиудаа тогтоосноос бусдаар бол тооныхоо хувьд нэгдмэл байсан хүмүүсийн овгууд шиг тийм хүчирхэг байсангүй; гэсэн хэдий ч тэд дайснууд байв; тэд зөв шударга хүмүүс байгаагүй хэдий ч, засгийн газрыг устгахаар гэрээнд орсон тэдэнд хонзогносондоо өөр хоорондоо нэгдсэн байв.

12 Тиймийн тул, Иаков дайснууд нь тэднээс илүү олон тоотойг хараад, тэрээр уг холбооны хаан байсан учир, тиймийн тул тэрслэгчдээр өргөжих хүртлээ, (учир нь тэрбээр олон тэрслэгчид байх болно хэмээн тэднийг зусардав) мөн тэд уг хүмүүсийн овгуудтай тэмцэх хангалттай хүчтэй болтлоо, тэд нутгийн алс умардын хэсэгт зугтан очиж, мөн тэнд өөрсдөө хаант улс босгохыг тэрбээр өөрийн хүмүүст зарлиг болгов; мөн тэд ийн үйлдэв.

13 Мөн тэдний жагсаал хүмүүс хүрэх зайнаас холдох хүртлээ саатуулагдахааргүй тийм хурдан байв. Мөн гучдугаар он ийн төгсөв; мөн Нифайн хүмүүсийн хэрэг явдлууд ийн байв.

14 Мөнхүү улиран тохиох дор гучин нэг дэх онд, хүн бүр өөрийн гэр бүл, төрөл садан хийгээд найз нөхдийнхөө дагуу тэд овгуудад хуваагдсан байв; гэсэн хэдий ч тэд нэг нэгэнтэйгээ дайтахаар явахгүй гэсэн тохиролцоонд хүрчээ; гэвч тэд хуулиудаараа, мөн засгийн газрын байдлаараа нэгдмэл бус байв, учир нь тэд толгойлогчид бөгөөд удирдагчид нь асан тэдний бодлын дагуу тогтоогдов. Харин тэд нэг овог нөгөөгийнхөө эсрэг халдахгүй гэсэн маш чанд хуулиудыг тогтоож, үүний хэрээр уг нутагт ямар нэгэн хэмжээгээр тэд амар амгалан байв; гэсэн хэдий ч, тэдний зүрх сэтгэл Их Эзэн Бурханаасаа эргэсэн байв, мөн тэд бошиглогчдыг чулуугаар шидэж мөн тэднийг өөрсдийн дундаас зайлуулан гаргажээ.

15 Мөнхүү улиран тохиох дор Нифай—тэнгэр элчүүдээр мөн түүнчлэн Их Эзэний дуу хоолойгоор зочлогдсон учир, тиймийн тул тэнгэр элчүүдийг харж, мөн нүдээр үзэн гэрч болж, мөн тэрбээр Христийн тохинууллын талаар мэдэж болохын тулд түүнд хүч өгөгдсөн байв, мөн түүнчлэн тэд зөв шударгаас ёс бусад мөн жигшүүрт хэргүүдэд хурдан эргэхийг нүдээр үзсэн гэрч байсан учир;

And it came to pass that they were not so strong in number as the tribes of the people, who were united together save it were their leaders did establish their laws, every one according to his tribe; nevertheless they were enemies; notwithstanding they were not a righteous people, yet they were united in the hatred of those who had entered into a covenant to destroy the government.

Therefore, Jacob seeing that their enemies were more numerous than they, he being the king of the band, therefore he commanded his people that they should take their flight into the northernmost part of the land, and there build up unto themselves a kingdom, until they were joined by dissenters, (for he flattered them that there would be many dissenters) and they become sufficiently strong to contend with the tribes of the people; and they did so.

And so speedy was their march that it could not be impeded until they had gone forth out of the reach of the people. And thus ended the thirtieth year; and thus were the affairs of the people of Nephi.

And it came to pass in the thirty and first year that they were divided into tribes, every man according to his family, kindred and friends; nevertheless they had come to an agreement that they would not go to war one with another; but they were not united as to their laws, and their manner of government, for they were established according to the minds of those who were their chiefs and their leaders. But they did establish very strict laws that one tribe should not trespass against another, insomuch that in some degree they had peace in the land; nevertheless, their hearts were turned from the Lord their God, and they did stone the prophets and did cast them out from among them.

And it came to pass that Nephi—having been visited by angels and also the voice of the Lord, therefore having seen angels, and being eye-witness, and having had power given unto him that he might know concerning the ministry of Christ, and also being eye-witness to their quick return from righteousness unto their wickedness and abominations;

- 16 Тиймийн тул, тэдний зүрх сэтгэлийнх нь хатуу мөн оюуных нь харалганы улмаас гашуудсан учир— мөнхүү онд тэдний дунд очиж, мөн Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр ирэх наманчлал хийгээд нүглүүдийн ангижралыг зоригтойгоор гэрчилж эхлэв.
- 17 Мөн тэрбээр тэдэнд олон зүйлийг тохинуулсан болой; мөн тэдгээр нь бүгд бичигдсэн байх аргагүй, мөн тэдгээрийн нэг хэсэг нь хангалттай бус болой, тиймийн тул тэдгээр нь энэ номонд бичигдсэнгүй. Мөн Нифай хүчтэйгээр мөн агуу эрх мэдэлтэйгээр тохинуулсан болой.
- 18 Мөнхүү улиран тохиох дор бүр тэрбээр тэднээс илүү агуу хүчтэй байснаас тэд түүнд уурлаж байв, учир нь тэд түүний үгсэд үл итгэх нь боломжгүй байлаа, учир нь Их Эзэн Есүс Христэд итгэх түүний итгэл агуу байснаас тэнгэр элчүүд түүнд өдөр бүр тохиноулж байв.
- 19 Мөн Есүсийн нэрээр тэр чөтгөрүүдийг мөн цэвэр бус сүнснүүдийг зайлуулав; мөн дүү нь хүмүүсээр чулуугаар шидүүлж үхлийг амссаны дараа тэрбээр түүнийг бүр нас барагсдаас босгосон болой.
- 20 Мөн хүмүүс үүнийг харж, мөн үүнийг үзэж, мөн түүний хүчний учир түүнд уурлаж байв; мөн түүнчлэн тэрбээр хүмүүсийн нүдэн дээр, Есүсийн нэрээр өөр олон гайхамшиг үйлджээ.
- 21 Мөнхүү улиран тохиох дор гучин нэгдүгээр он улирч одов, мөн Их Эзэнд зөвхөн цөөн хэд нь хөрвүүлэгдэв; харин хөрвүүлэгдсэн болгон нь өөрсдийн итгэсэн түүнд, Есүс Христэд байсан Бурханы Сүнс мөн хүчээр зочлогдсоноо уг хүмүүст үнэхээр харуулсан болой.
- 22 Мөн чөтгөрүүд зайлуулагдав, мөн өвчин болон шаналлаасаа эдгээгдсэн болгон, Бурханы Сүнсээр тэд нөлөөлөгдсөн мөн эдгээгдсэнийг уг хүмүүст үнэхээр мэдүүлжээ; мөн тэд тэмдгүүдийг түүнчлэн үзүүлж мөн хүмүүсийн дунд зарим гайхамшгуудыг үйлдсэн бөлгөө.
- 23 Ийн гучин хоёрдугаар он түүнчлэн улирч одов. Мөн гучин гуравдугаар оны эхэнд Нифай хүмүүст тунхаглаж; мөн тэрбээр тэдэнд наманчлал хийгээд нүглүүдийн ангижралыг номлов.

Therefore, being grieved for the hardness of their hearts and the blindness of their minds—went forth among them in that same year, and began to testify, boldly, repentance and remission of sins through faith on the Lord Jesus Christ.

And he did minister many things unto them; and all of them cannot be written, and a part of them would not suffice, therefore they are not written in this book. And Nephi did minister with power and with great authority.

And it came to pass that they were angry with him, even because he had greater power than they, for it were not possible that they could disbelieve his words, for so great was his faith on the Lord Jesus Christ that angels did minister unto him daily.

And in the name of Jesus did he cast out devils and unclean spirits; and even his brother did he raise from the dead, after he had been stoned and suffered death by the people.

And the people saw it, and did witness of it, and were angry with him because of his power; and he did also do many more miracles, in the sight of the people, in the name of Jesus.

And it came to pass that the thirty and first year did pass away, and there were but few who were converted unto the Lord; but as many as were converted did truly signify unto the people that they had been visited by the power and Spirit of God, which was in Jesus Christ, in whom they believed.

And as many as had devils cast out from them, and were healed of their sicknesses and their infirmities, did truly manifest unto the people that they had been wrought upon by the Spirit of God, and had been healed; and they did show forth signs also and did do some miracles among the people.

Thus passed away the thirty and second year also. And Nephi did cry unto the people in the commencement of the thirty and third year; and he did preach unto them repentance and remission of sins.

24 Эдүгээ наманчлалд авчрагдсан тэднээс баптисм хүртээгүй нэг нь ч байсангүйг та нар түүнчлэн санаасай хэмээнэ би.

25 Тиймийн тул, тэдэнд ирэх бүгд нь баптисм хүртээхийн тулд энэхүү тохинуулалд Нифайгаар томилогдсон эрчүүд байлаа; мөн энэ нь Бурханы өмнө, мөн уг хүмүүст, тэд наманчилсан мөн нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авсны гэрч мөн нотолгоо байв.

26 Мөн энэ оны эхэнд наманчлалд хүргэн баптисм хүртсэн нь олон байв; мөн ийн жилийн ихэнх хэсэг улирч одов.

Now I would have you to remember also, that there were none who were brought unto repentance who were not baptized with water.

Therefore, there were ordained of Nephi, men unto this ministry, that all such as should come unto them should be baptized with water, and this as a witness and a testimony before God, and unto the people, that they had repented and received a remission of their sins.

And there were many in the commencement of this year that were baptized unto repentance; and thus the more part of the year did pass away.

### 3 Нифай 8

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор бидний цэдгийн дагуу, мөн бидний цэдэг үнэн болохыг бид мэднэ, учрыг болгоогтун, уг цэдгийг хөтөлсөн тэр нь шударга хүн байв—учир нь тэрбээр Есүсийн нэрээр олон гайхамшиг үнэхээр үйлдсэн бөлгөө; мөн тэрбээр, алдсаасаа өчүүхэн хэсэг бүр нь цэвэрлэгдээгүй аваас Есүсийн нэрээр гайхамшиг үйлдэж чадах ямар ч хүн үгүй билээ—
- 2 Мөн эдүгээ улиран тохиох дор, бидний цаг үеийг тооцоолохдоо энэ хүнээр алдаа хийгдээгүй бол, гучин гуравдугаар он тийн улирч одсон байв;
- 3 Мөн лемен үндэстэн, бошиглогч Самуелаар өгөгдсөн байсан тэмдгийг, тийм ээ, уг нутгийн гадаргуу дээр гурав хоногийн турш харанхуй байх тэр цагийг хүмүүс маш ихээр идэвхийлэн харж эхлэв.
- 4 Мөн ийм олон тэмдэг өгөгдсөн хэдий ч, хүмүүсийн дунд агуу эргэлзээ хийгээд сэргэлдөөнүүд байж эхлэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор гучин дөрөвдүгээр онд, эхний сард, уг сарын дөрөв дэх өдөр, бүх нутагт урьд хожид мэдэгдэж байгаагүй тийм нэгэн их шуурга босов.
- 6 Мөн түүнчлэн агуу хийгээд аймшигт их салхи байв; мөн аймшигт аянга бууж, үүний хэрээр энэ нь бүхэл газар дэлхийг хоёр хэсэг хуваах гэж байгаа мэт сэгсрэв.
- 7 Мөн бүх нутагт хэзээ ч үзэгдэж байгаагүй тийм үлэмж хурц цахилгаан цахив.
- 8 Мөн Зарахемла хот түймэрт шатаж эхлэв.
- 9 Мөн Моронай хот тэнгисийн гүнд живж, мөн оршин суугчид нь живж үхэв.
- 10 Мөн Моронайха хотын дээр газар зөөгдсөнөөс, хотын оронд агуу том уул байх болов.
- 11 Мөн өмнөд хэсгийн нутагт агуу хийгээд аймшигт устгал байв.

### 3 Nephi 8

And now it came to pass that according to our record, and we know our record to be true, for behold, it was a just man who did keep the record—for he truly did many miracles in the name of Jesus; and there was not any man who could do a miracle in the name of Jesus save he were cleansed every whit from his iniquity—

And now it came to pass, if there was no mistake made by this man in the reckoning of our time, the thirty and third year had passed away;

And the people began to look with great earnestness for the sign which had been given by the prophet Samuel, the Lamanite, yea, for the time that there should be darkness for the space of three days over the face of the land.

And there began to be great doubtings and disputations among the people, notwithstanding so many signs had been given.

And it came to pass in the thirty and fourth year, in the first month, on the fourth day of the month, there arose a great storm, such an one as never had been known in all the land.

And there was also a great and terrible tempest; and there was terrible thunder, insomuch that it did shake the whole earth as if it was about to divide asunder.

And there were exceedingly sharp lightnings, such as never had been known in all the land.

And the city of Zarahemla did take fire.

And the city of Moroni did sink into the depths of the sea, and the inhabitants thereof were drowned.

And the earth was carried up upon the city of Moronihah, that in the place of the city there became a great mountain.

And there was a great and terrible destruction in the land southward.

- 12 Гэвч болгоогтун, умардын нутагт илүү агуу хийгээд аймшигт устгал байв; учрыг болгоогтун, уг нутгийн бүх гадаргуу өөрчлөгдөв, шуурга мөн салхин хүрд, мөн аянга болон цахилгаан, мөн бүх газар үлэмж агуу ихээр хөдөлсний улмаас болой;
- 13 Мөн их хөлийн замууд хагарч, мөн толигор замууд эвдэрч, мөн олон тэгш газар олон товон болжээ.
- 14 Мөн олон агуу хийгээд алдартай хотууд живж, мөн олон нь шатаагдаж, мөн олон нь сэгсрэгдэж, барилгууд нь газарт унах хүртэл, мөн оршин суугчид нь эрсдэж, мөн уг газрууд эзгүйрэн орхигдов.
- 15 Мөн үлдэж хоцорсон зарим хотууд байлаа; гэвч эвдрэл нь үлэмж агуу байж, мөн тэдний дотор эрсэдсэн нь олон байв.
- 16 Мөн салхин хүрдэнд хийсэн одсон зарим нь байв; мөн тэдний хийсэн одсоныг гэдгийг тэд мэдэхээс бус, тэдний хааш одсоныг нэг ч хүн мэдэхгүй байв.
- 17 Мөн тийн бүхэл газар дэлхийн гадаргуу, шуурга, мөн аянга, мөн цахилгаан, мөн газар хөдлөлтүүдийн улмаас хэлбэр нь алдагдсан байв.
- 18 Мөн болгоогтун, хаднууд хоёр хэсэгт цуурч хагарав; тэдгээр нь бүх л газар дэлхийн гадаргуу дээр хагарав, үүний хэрээр тэдгээр нь хагарсан хэлтэрхийнүүд болж, мөн үе давхаргуудад мөн хагархайд, уг нутгийн бүх гадаргуу дээр хэвтэх болов.
- 19 Мөнхүү улиран тохиох дор аянга, мөн цахилгаан, мөн шуурга, мөн их салхи, мөн газар хөдлөлтүүд зогсоход—учир нь болгоогтун, тэдгээр нь барагцаалбал гурван цагийн турш үргэлжлэв; мөн илүү хугацаатай байсан хэмээн заримаар нь хэлэгдэв; гэсэн хэдий ч, эдгээр бүр агуу хийгээд аймшигт зүйлүүд барагцаалбал гурван цагийн хугацаанд болов—мөн тэгэхэд болгоогтун, уг нутгийн гадаргуу дээр харанхуй байв.
- 20 Мөнхүү улиран тохиох дор өтгөн харанхуй нь уг нутгийн бүх гадаргуу дээр байв, үүний хэрээр үүний үхээгүй байсан оршин суугчид харанхуйн мананг мэдрэхүйц байв;

But behold, there was a more great and terrible destruction in the land northward; for behold, the whole face of the land was changed, because of the tempest and the whirlwinds, and the thunderings and the lightnings, and the exceedingly great quaking of the whole earth;

And the highways were broken up, and the level roads were spoiled, and many smooth places became rough.

And many great and notable cities were sunk, and many were burned, and many were shaken till the buildings thereof had fallen to the earth, and the inhabitants thereof were slain, and the places were left desolate.

And there were some cities which remained; but the damage thereof was exceedingly great, and there were many in them who were slain.

And there were some who were carried away in the whirlwind; and whither they went no man knoweth, save they know that they were carried away.

And thus the face of the whole earth became deformed, because of the tempests, and the thunderings, and the lightnings, and the quaking of the earth.

And behold, the rocks were rent in twain; they were broken up upon the face of the whole earth, insomuch that they were found in broken fragments, and in seams and in cracks, upon all the face of the land.

And it came to pass that when the thunderings, and the lightnings, and the storm, and the tempest, and the quakings of the earth did cease—for behold, they did last for about the space of three hours; and it was said by some that the time was greater; nevertheless, all these great and terrible things were done in about the space of three hours—and then behold, there was darkness upon the face of the land.

And it came to pass that there was thick darkness upon all the face of the land, insomuch that the inhabitants thereof who had not fallen could feel the vapor of darkness;

- 21 Мөн уг харанхуйн учир ямар ч гэрэл, лаа ч, бас бамбар ч байх аргагүй байлаа; бас сайн мөн үлэмж хуурай модоор ч гал асаагдах аргагүй байв, иймээс ямар ч гэрэл огт байх аргагүй байлаа;
- 22 Мөн ямар ч гэрэл, бас түүдэг, бас сүүмэлзэх төдий гэрэл ч, бас нар, бас сар, бас одод ч харагдахгүй байв, учир нь уг нутгийн гадаргуу дээрх харанхуйн манан тийм агуу байв.
- 23 Мөнхүү улиран тохиох дор энэ нь гурав хоног үргэлжилснээс тэнд ямар ч гэрэл харагдахгүй байв; мөн агуу гашуудал мөн гаслан мөн уйлаан бүх хүмүүсийн дунд үргэлжлэн байв; тийм ээ, хүмүүсийн ёолон гаслах нь агуу байв, тэдний дээр ирсэн тэрхүү харанхуй нь мөн агуу устгалын улмаас болой.
- 24 Мөн нэг газар уйлж, өгүүлсэн нь: Ай энэ агуу хийгээд гамшигт өдрийн өмнө бид наманчилсан болоосой, мөн тэгсэн бол ах дүүс маань хэлтрүүлэгдсэн байх сан, мөн тэд агуу хот Зарахемлад шатаагдахгүй байх сан билээ хэмээн тэдний хэлэх нь сонсогдов.
- 25 Өөр нэг газар уйлж мөн гашуудаж, өгүүлсэн нь: Ай энэ агуу хийгээд аймшигт өдрийн өмнө бид наманчлан, мөн бошиглогчдыг хөнөөж мөн чулуугаар шидээгүй, мөн тэднийг зайлуулаагүй ч болоосой; тэгсэн бол ээжүүд маань мөн хонгорхон охид минь, мөн хүүхдүүд маань хэлтрүүлэгдсэн байхсан, мөн агуу хот Моронайхад булагдахгүй байхсан гэх нь сонсогдов. Мөн тийн хүмүүсийн гаслан агуу хийгээд аймшигтай байв.

And there could be no light, because of the darkness, neither candles, neither torches; neither could there be fire kindled with their fine and exceedingly dry wood, so that there could not be any light at all;

And there was not any light seen, neither fire, nor glimmer, neither the sun, nor the moon, nor the stars, for so great were the mists of darkness which were upon the face of the land.

And it came to pass that it did last for the space of three days that there was no light seen; and there was great mourning and howling and weeping among all the people continually; yea, great were the groanings of the people, because of the darkness and the great destruction which had come upon them.

And in one place they were heard to cry, saying: O that we had repented before this great and terrible day, and then would our brethren have been spared, and they would not have been burned in that great city Zarahemla.

And in another place they were heard to cry and mourn, saying: O that we had repented before this great and terrible day, and had not killed and stoned the prophets, and cast them out; then would our mothers and our fair daughters, and our children have been spared, and not have been buried up in that great city Moronihah. And thus were the howlings of the people great and terrible.

### 3 Нифай 9

- 1 Мөнхүү улиран тохиох дор газар дэлхийн бүх оршин суугчдын дунд, энэ нутгийн бүх гадаргуу дээр нэгэн дуу хоолой сонсогдож, чангаар ярьсан нь:
- 2 Ай халаг, энэ хүмүүст халаг, халаг; тэд наманчлахгүй аваас бүх газар дэлхийн оршин суугчдад халаг; учир нь, миний хүмүүсийн хонгорхон хөвгүүд мөн охидын алагдагсдын учир чөтгөр хөхөрч, мөн түүний элчүүд баясах ажгуу; мөн тэдний унасан нь алдас мөн жигшүүрт хэргүүдийнх нь учир болой!
- 3 Болгоогтун, агуу хот Зарахемлаг, мөн оршин суугчдыг нь би түймэрт шатаасан.
- 4 Мөн болгоогтун, тэр агуу хот Моронайг би тэнгисийн гүнд живүүлж, мөн оршин суугчдыг нь живж үхэх болгосон.
- 5 Мөн болгоогтун, тэдний алдсууд хийгээд жигшүүрт хэргүүдийг өөрийн нүүрнээс далд оруулахаар, бошиглогчдын болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг надад хойшид ирэхгүй байхын тулд агуу хот Моронайхаг, мөн түүний оршин суугчдыг нь би газраар хучсан.
- 6 Мөн болгоогтун, Гилгалын хотыг би булагдах болгож, мөн оршин суугчдыг нь газрын гүнд булшлагдахаар болгосон;
- 7 Тийм ээ, мөн Онаиха хот мөн түүний оршин суугчид мөн Мокумын хот мөн түүний оршин суугчид, мөн Иерусалимын хот мөн түүний оршин суугчдыг; мөн тэдний алдсууд хийгээд жигшүүрт хэргүүдийг нүүрнээсээ далд оруулан нуухын тулд, бошиглогчид болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг хойшид надад ирэхгүйн тулд, тэдгээрийн оронд ус байхаар болгосон би.
- 8 Мөн болгоогтун, Гадиандайн хот, мөн Гадиомнагийн хот, мөн Иаковын хот, Гимгимнагийн хот, эдгээр бүгдийг булагдах болгосон би, мөн түүний оронд толгод мөн хөндийнүүд болгосон; мөн тэдний ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийг нүүрнээсээ далд оруулахын тулд, бошиглогчдын болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг хойшид надад ирэхгүй байхын тулд оршин суугчдыг нь газрын гүнд булшилсан би.

### 3 Nephi 9

And it came to pass that there was a voice heard among all the inhabitants of the earth, upon all the face of this land, crying:

Wo, wo, wo unto this people; wo unto the inhabitants of the whole earth except they shall repent; for the devil laugheth, and his angels rejoice, because of the slain of the fair sons and daughters of my people; and it is because of their iniquity and abominations that they are fallen!

Behold, that great city Zarahemla have I burned with fire, and the inhabitants thereof.

And behold, that great city Moroni have I caused to be sunk in the depths of the sea, and the inhabitants thereof to be drowned.

And behold, that great city Moronihah have I covered with earth, and the inhabitants thereof, to hide their iniquities and their abominations from before my face, that the blood of the prophets and the saints shall not come any more unto me against them.

And behold, the city of Gilgal have I caused to be sunk, and the inhabitants thereof to be buried up in the depths of the earth;

Yea, and the city of Onihah and the inhabitants thereof, and the city of Mocum and the inhabitants thereof, and the city of Jerusalem and the inhabitants thereof; and waters have I caused to come up in the stead thereof, to hide their wickedness and abominations from before my face, that the blood of the prophets and the saints shall not come up any more unto me against them.

And behold, the city of Gadiandi, and the city of Gadiomnah, and the city of Jacob, and the city of Gim gimno, all these have I caused to be sunk, and made hills and valleys in the places thereof; and the inhabitants thereof have I buried up in the depths of the earth, to hide their wickedness and abominations from before my face, that the blood of the prophets and the saints should not come up any more unto me against them.

9 Мөн болгоогтун, хаан Иаковын хүмүүсийн оршин суусан агуу хот Иаковогафыг тэдний нууц аллагууд мөн бүлэглэлийн учир, бүх газар дэлхийн бүхий л ёс бусаас илүү, тэдний нүглүүд мөн ёс бусынх нь учир түймэрт шатаахаар болгосон би; учир нь миний хүмүүсийн амар амгаланг мөн уг нутгийн засгийн газрыг устгасан нь тэд болой; тиймийн тул тэднийг нүүрнээсээ далд оруулан устгахын тулд, бошиглогчид болон гэгээнтнүүдийн цус тэдний эсрэг хойшид надад ирэхгүйн тулд тэднийг шатаагдах болгосон би.

10 Мөн болгоогтун, Леменийн хот, мөн Жошийн хот, мөн Гадын хот, мөн Кишкүменийн хотыг, мөн тэдгээрийн оршин суугчдыг бошиглогчдыг зайлуулсан, мөн тэдний жигшүүрт хэргүүдийнх нь талаар тэдэнд тунхаглуулахаар миний илгээсэн тэднийг чулуугаар шидсэн ёс бусынх нь учир түймэрт шатаагдах болгосон би.

11 Мөн эдгээр бүгдийг тэд зайлуулснаас тэдний дунд зөв шударгыг үйлдэгсэд үгүй байсан учир, тэдний ёс бус хийгээд жигшүүрт хэргүүд миний нүүрнээс далд орохын тулд, тэдний дунд миний илгээсэн бошиглогчид болон гэгээнтнүүдийн цус газраас тэдний эсрэг надад хашгирахгүй байж болохын тулд би доош галыг илгээж мөн тэднийг устгасан.

12 Мөн олон агуу устгалуудыг, мөн энэ хүмүүсийн дээр, тэдний ёс бус мөн жигшүүрт хэргүүдийнх нь учир энэ нутагт ирэхээр болгосон би.

13 Тэднээс илүү зөв шударга байснаас, Ай хэлтрүүлэгдсэн та нар бүгд, эдүгээ би та нарыг эдгээж болохын тулд та нар надад эргэн ирж, мөн нүглүүдээ наманчилж, мөн хөрвүүлэгдэхгүй гэж үү

14 Тийм ээ, үнэнээр би та нарт хэлнэ, хэрэв та нар надад ирэх аваас та нар мөнх амьдралыг авах болно. Болгоогтун, миний нигүүлслийн мутар та нарын зүг сунгаастай байна, мөн ирэх хэнийг боловч, түүнийг би хүлээн авах болно; мөн надад ирэх тэд адислагдсан болой.

15 Болгоогтун, би бол Бурханы Хүү Есүс Христ бөлгөө. Би тэнгэр ба газрыг, мөн тэдгээрийн дээрх бүх зүйлийг бүтээсэн билээ. Би эхлэлээс Эцэгтэй хамт байсан. Би Эцэгт буй, мөн Эцэг надад буй; мөн Эцэг нэрээ надаар алдаршуулсан болой.

And behold, that great city Jacobugath, which was inhabited by the people of king Jacob, have I caused to be burned with fire because of their sins and their wickedness, which was above all the wickedness of the whole earth, because of their secret murders and combinations; for it was they that did destroy the peace of my people and the government of the land; therefore I did cause them to be burned, to destroy them from before my face, that the blood of the prophets and the saints should not come up unto me any more against them.

And behold, the city of Laman, and the city of Josh, and the city of Gad, and the city of Kishkumen, have I caused to be burned with fire, and the inhabitants thereof, because of their wickedness in casting out the prophets, and stoning those whom I did send to declare unto them concerning their wickedness and their abominations.

And because they did cast them all out, that there were none righteous among them, I did send down fire and destroy them, that their wickedness and abominations might be hid from before my face, that the blood of the prophets and the saints whom I sent among them might not cry unto me from the ground against them.

And many great destructions have I caused to come upon this land, and upon this people, because of their wickedness and their abominations.

O all ye that are spared because ye were more righteous than they, will ye not now return unto me, and repent of your sins, and be converted, that I may heal you?

Yea, verily I say unto you, if ye will come unto me ye shall have eternal life. Behold, mine arm of mercy is extended towards you, and whosoever will come, him will I receive; and blessed are those who come unto me.

Behold, I am Jesus Christ the Son of God. I created the heavens and the earth, and all things that in them are. I was with the Father from the beginning. I am in the Father, and the Father in me; and in me hath the Father glorified his name.



- 16 Би өөрийнхөндөө ирсэн, гэтэл өөрийнхөн маань намайг хүлээн авсангүй. Мөн миний ирэлтийн талаарх судрууд гүйцэлдсэн болой.
- 17 Мөн намайг хүлээн авсан болгонд, Бурханы хөвгүүд болохыг би тэдэнд зөвшөөрсөн; мөн бүр миний нэрэнд итгэх болгонд би зөвшөөрөх болно, учир нь болгоогтун, надаар гэтэлгэл ирдэг, мөн надаар Мосегийн хууль гүйцэлдсэн бөлгөө.
- 18 Би бол дэлхийн гэрэл ба амь. Би бол Альфа ба Омега, эхлэл ба төгсгөл.
- 19 Мөн та нар цаашид цус урсган надад өргөл өргөхгүй; тийм ээ, та нарын тахилууд мөн хайлах өргөл тань зогсоогдох болно, учир нь би та нарын тахилууд мөн хайлсан өргөлүүдээс тань алийг нь ч хүлээн авахгүй.
- 20 Мөн та нар харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг надад өргөл болгон өргөх болно. Мөн харууссан зүрх гэмшсэн сэтгэлтэйгээр надад ирэх хэнд боловч, түүнд би галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртээнэ, бүр леменчүүдийн хөрвүүлгийн үе дэх надад итгэх тэдний итгэлийн учир, тэд галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртсэн, бөгөөд үүнийг тэд мэдээгүй билээ.
- 21 Болгоогтун, дэлхийнхэнд гэтэлгэл авчрахаар, дэлхийнхнийг нүглээс нь аврахаар би дэлхийнхэнд ирсэн бөлгөө.
- 22 Тиймийн тул, наманчилж мөн бяцхан хүүхдийн адил надад ирэх хэнийг боловч, би түүнийг хүлээн авах болно, учир нь Бурханы хаант улс бол ийм хүмүүсийнх юм. Болгоогтун, ийм хүмүүсийн төлөө би амиа өгч, мөн үүнийгээ буцаан авсан юм; тиймийн тул наманчил, мөн дэлхийн хязгаарууд та нар надад ир, мөн аврагдагтун.

I came unto my own, and my own received me not.  
And the scriptures concerning my coming are fulfilled.

And as many as have received me, to them have I given to become the sons of God; and even so will I to as many as shall believe on my name, for behold, by me redemption cometh, and in me is the law of Moses fulfilled.

I am the light and the life of the world. I am Alpha and Omega, the beginning and the end.

And ye shall offer up unto me no more the shedding of blood; yea, your sacrifices and your burnt offerings shall be done away, for I will accept none of your sacrifices and your burnt offerings.

And ye shall offer for a sacrifice unto me a broken heart and a contrite spirit. And whoso cometh unto me with a broken heart and a contrite spirit, him will I baptize with fire and with the Holy Ghost, even as the Lamanites, because of their faith in me at the time of their conversion, were baptized with fire and with the Holy Ghost, and they knew it not.

Behold, I have come unto the world to bring redemption unto the world, to save the world from sin.

Therefore, whoso repenteth and cometh unto me as a little child, him will I receive, for of such is the kingdom of God. Behold, for such I have laid down my life, and have taken it up again; therefore repent, and come unto me ye ends of the earth, and be saved.

### 3 Нифай 10

- 1 Мөн эдүгээ болгоогтун, улиран тохиох дор уг нутгийн бүх хүмүүс эдгээр үгсийг сонсож, мөн үүнийг үзсэн болой. Мөн эдгээр үгсийн дараа уг нутагт олон цагийн туршид нам гүм байв;
- 2 Учир нь уг хүмүүсийн гайхашрал агуу байснаас тэд эрсэдсэн садан төрлөө алдсандаа халаглах мөн гаслахаа болив; тиймийн тул бүх нутагт олон цагийн туршид нам гүм байв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор уг хүмүүст дахин нэгэн дуу хоолой ирж, мөн бүх хүмүүс сонсож, мөн үүний гэрч болов, тэр нь өгүүлсэн нь:
- 4 Ай унасан эдгээр агуу их хотын хүмүүс, Иаковын удмынхан болох, тийм ээ, Израилын угсаа болох та нар, эм тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулж мөн асарсан билээ.
- 5 Мөн тэрчлэн, тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулахсан хэмээв, тийм ээ, Ай Израилын угсааны унасан хүмүүс та нар; тийм ээ, Ай Израилын угсааны хүмүүс та нар, унасан та нар мөн түүнчлэн Иерусалимд орших та нар; тийм ээ, тахиа дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг би та нарыг хичнээн ч удаа цуглуулахсан хэмээв, мөн та нар цугласангүй.
- 6 Ай миний хэлтрүүлсэн Израилын угсаа та нар, хэрэв та нар наманчилж мөн зүрх сэтгэлийнхээ бүрэн тэмүүлээр надад эргэж ирэх аваас, тахиа далавчин дороо дэгдээхийнүүдээ цуглуулдаг шиг хичнээн ч удаа би та нарыг цуглуулах билээ.
- 7 Гэвч эс тэгвээс, Ай Израилын угсаа, та нарын оршин буй газрууд тань эцэг өвгөдтэй чинь хийсэн гэрээний гүйцэтгэлийн цагийг хүртэл эзгүй байх болно.
- 8 Мөн эдүгээ улиран тохиох дор уг хүмүүс эдгээр үгсийг сонссоныхоо дараа, болгоогтун, тэд садан төрөл мөн найз нөхдөө алдсаныхаа улмаас дахин уйлж мөн гасалж эхлэв.

### 3 Nephi 10

And now behold, it came to pass that all the people of the land did hear these sayings, and did witness of it. And after these sayings there was silence in the land for the space of many hours;

For so great was the astonishment of the people that they did cease lamenting and howling for the loss of their kindred which had been slain; therefore there was silence in all the land for the space of many hours.

And it came to pass that there came a voice again unto the people, and all the people did hear, and did witness of it, saying:

O ye people of these great cities which have fallen, who are descendants of Jacob, yea, who are of the house of Israel, how oft have I gathered you as a hen gathereth her chickens under her wings, and have nourished you.

And again, how oft would I have gathered you as a hen gathereth her chickens under her wings, yea, O ye people of the house of Israel, who have fallen; yea, O ye people of the house of Israel, ye that dwell at Jerusalem, as ye that have fallen; yea, how oft would I have gathered you as a hen gathereth her chickens, and ye would not.

O ye house of Israel whom I have spared, how oft will I gather you as a hen gathereth her chickens under her wings, if ye will repent and return unto me with full purpose of heart.

But if not, O house of Israel, the places of your dwellings shall become desolate until the time of the fulfilling of the covenant to your fathers.

And now it came to pass that after the people had heard these words, behold, they began to weep and howl again because of the loss of their kindred and friends.

- 9 Мөнхүү улиран тохиох дор гурван өдөр тийн улирч одов. Мөн энэ нь өглөө байж, мөн уг нутгийн гадаргуу дээрээс харанхуй сарниж, мөн газар чичрэхээ больж, мөн хаднууд цуурахаа больж, мөн аймаар ёолон гаслах нь зогсож, мөн бүх үймээн шуугианууд нь улирч одов.
- 10 Мөн газар дахин нэгдэн нийлснээс, энэ нь тэсэж өнгөрөв; мөн амь хэлтрүүлэгдсэн хүмүүсийн гашуудах нь, мөн уйлах нь, мөн ёолон гаслах нь зогссон болой; мөн тэдний гашуудах нь баясалд, мөн тэдний халаглах нь магтан дуулахад мөн Их Эзэн Есүс Христ, өөрсдийн Гэтэлгэгчид талархахад шилжсэн байв.
- 11 Мөн бошиглогчдоор яригдсан судрууд өдийг хүртэл гүйцэлдэв.
- 12 Мөн аврагдсан нь уг хүмүүсийн илүү зөв шударга нь байв, мөн бошиглогчдыг хүлээн авч мөн тэднийг чулуугаар шидээгүй нь тэд байв; мөн гэгээнтнүүдийн цусыг урсгаагүй нь тэд байв, хэлтрүүлэгдсэн тэд буюу—
- 13 Мөн тэд хэлтрүүлэгдсэн мөн живээгүй мөн газарт булагдаагүй; мөн тэд тэнгисийн гүнд живүүлэгдсэнгүй; мөн тэд гүймрээр шатаагдсангүй, бас тэд дарагдаж мөн үхтлээ няцлагдсангүй; мөн тэд хуй салхинд хийсч одсонгүй; бас тэд утаан мөн харанхуйн мананд автагдсангүй.
- 14 Мөн эдүгээ, унших хэн боловч тэр нь ойлгог; судрууд бүхий тэр нь тэдгээрийг судлаг, мөн гүймрээр, мөн утаагаар, мөн их салхиар, мөн хуйгаар, мөн тэднийг авах газрын ангалаар эдгээр бүх үхлүүд хийгээд устгалууд, мөн эдгээр бүх зүйл ариун бошиглогчдын олных нь бошиглолуудыг гүйцэлдүүлсэн эсэхийг харж мөн болгоог.
- 15 Болгоогтун, би та нарт хэлнэ, Тийм ээ, олон нь Христийн ирэлтийн үед эдгээр зүйлийг гэрчилж, мөн тэд эдгээр зүйлсийг гэрчилсэн учир хөнөөгдсөн болой.
- 16 Тийм ээ, бошиглогч Зинос эдгээр зүйлийг гэрчилсэн, мөн түүнчлэн Зинок эдгээр зүйлийн талаар ярьсан, учир нь тэдний үр удмын үлдэгдэл болох бидний талаар онцгойлон гэрчилсэн болой.

And it came to pass that thus did the three days pass away. And it was in the morning, and the darkness dispersed from off the face of the land, and the earth did cease to tremble, and the rocks did cease to rend, and the dreadful groanings did cease, and all the tumultuous noises did pass away.

And the earth did cleave together again, that it stood; and the mourning, and the weeping, and the wailing of the people who were spared alive did cease; and their mourning was turned into joy, and their lamentations into the praise and thanksgiving unto the Lord Jesus Christ, their Redeemer.

And thus far were the scriptures fulfilled which had been spoken by the prophets.

And it was the more righteous part of the people who were saved, and it was they who received the prophets and stoned them not; and it was they who had not shed the blood of the saints, who were spared—

And they were spared and were not sunk and buried up in the earth; and they were not drowned in the depths of the sea; and they were not burned by fire, neither were they fallen upon and crushed to death; and they were not carried away in the whirlwind; neither were they overpowered by the vapor of smoke and of darkness.

And now, whoso readeth, let him understand; he that hath the scriptures, let him search them, and see and behold if all these deaths and destructions by fire, and by smoke, and by tempests, and by whirlwinds, and by the opening of the earth to receive them, and all these things are not unto the fulfilling of the prophecies of many of the holy prophets.

Behold, I say unto you, Yea, many have testified of these things at the coming of Christ, and were slain because they testified of these things.

Yea, the prophet Zenos did testify of these things, and also Zenock spake concerning these things, because they testified particularly concerning us, who are the remnant of their seed.

17 Болгоогтун, бидний өвөг Иаков түүнчлэн Иосефын үр удмын үлдэгдлийн талаар гэрчилсэн билээ. Мөн болгоогтун, бид Иосефын үр удмын үлдэгдэл биш гэж үү? Мөн бидний тухай гэрчлэх эдгээр зүйлүүд, бидний өвөг Лихай Иерусалимаас авчирсан гуулин ялтсууд дээр бичиглэгдсэн байгаа бус уу

18 Мөнхүү улиран тохиох дор гучин дөрөвдүгээр оны төгсгөлд, болгоогтун, хэлтрүүлэгдсэн Нифайн хүмүүс, мөн түүнчлэн хэлтрүүлэгдсэн леменчүүд гэж нэрлэгдсэн, тэдэнд агуу халамжууд үзүүлэгдсэнийг, мөн агуу адислалууд тэдний тэргүүн дээр цутгагдсаныг, үүний хэрээр Христ тэнгэрт дээшилсний дараахан тэрбээр үнэхээр тэдэнд өөрийгөө үзүүлснийг би та нарт харуулах болно—

19 Өөрийн биеийг тэдэнд үзүүлж, мөн тэдэнд тохинуулсан бөлгөө; мөн түүний тохинууллын шастир цаашид өгөгдөх болно. Тиймийн тул одоогоор би үгсээ төгсгөл болгоё.

Behold, our father Jacob also testified concerning a remnant of the seed of Joseph. And behold, are not we a remnant of the seed of Joseph? And these things which testify of us, are they not written upon the plates of brass which our father Lehi brought out of Jerusalem?

And it came to pass that in the ending of the thirty and fourth year, behold, I will show unto you that the people of Nephi who were spared, and also those who had been called Lamanites, who had been spared, did have great favors shown unto them, and great blessings poured out upon their heads, insomuch that soon after the ascension of Christ into heaven he did truly manifest himself unto them—

Showing his body unto them, and ministering unto them; and an account of his ministry shall be given hereafter. Therefore for this time I make an end of my sayings.

*Олон хүн Өгөөмөр нутагт нэгдэн цугларахад, Есүс Христ өөрийгөө Нифайн хүмүүст үзүүлж, мөн тэдэнд тохируулсан болой; мөн энэ маягаар тэрбээр тэдэнд өөрийгөө үзүүлэв.*

### 3 Нифай 11

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Нифайн хүмүүсээс, Өгөөмөр нутаг дахь ариун сүмийн эргэн тойронд нэгдэн цугларцгаасан их олон хүмүүс байв; мөн тэд болсон тэрхүү агуу хийгээд гайхамшигт өөрчлөлтийг нэг нэгэндээ заан үзүүлж, мөн гайхаж бас гайхширан нэг нэгэнтэйгээ ярьж байв.
- 2 Мөн түүний үхлийн талаар өгөгдсөн тэмдэг хамаарах энэхүү Есүс Христийн тухай тэд түүнчлэн ярилцаж байлаа.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэд тийн бие биентэйгээ ярилцаж байх хооронд, тэд тэнгэрээс ирэх мэт нэгэн дуу хоолойг сонсов; мөн тэд эргэн тойрондоо хараа бэлчээв, учир нь тэд сонссон тэр дуу хоолойг ойлгосонгүй; мөн энэ нь хүйтэн хөндий дуу хоолой, бас чанга дуу хоолой ч бус байв; гэсэн хэдий ч, энэ нь намуухан дуу хоолой байсан ч гэсэн, сонссон тэдний биенийх нь төвд нэвтрэн орж, үүний хэрээр салглаагүй тэдний биеийн нэг ч хэсэг байсангүй; тийм ээ, энэ нь тэдэнд чухам бодгальд нь нэвтрэн орж, мөн тэдний зүрх сэтгэлийг шатах мэт болгож байв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэд уг дуу хоолойг дахин сонсоод мөн тэд үүнийг ойлгосонгүй.
- 5 Мөн гурав дахь удаагаа тэд уг дуу хоолойг дахин сонсож, мөн үүнийг сонсохоор сонороо дэлгэв; мөн тэдний харц дуу гарсан зүгт чиглэв; мөн тэд тэрхүү дуу хоолой ирсэн тэнгэрийн зүг тууштайгаар ажиглаж байв.
- 6 Мөн болгоогтун, гурав дахь удаад нь тэд сонссон тэр дуу хоолойгоо ойлгосон болой; мөн энэ нь тэдэнд хэлэв:
- 7 Миний Хайрт Хүүг, миний ихэд таалсан түүнийг, би өөрийнхөө нэрийг алдаршуулсан түүнийг болгоогтун—та нар түүнийг анхааран сонсогтун.

*Jesus Christ did show himself unto the people of Nephi, as the multitude were gathered together in the land Bountiful, and did minister unto them; and on this wise did he show himself unto them.*

### 3 Nephi 11

And now it came to pass that there were a great multitude gathered together, of the people of Nephi, round about the temple which was in the land Bountiful; and they were marveling and wondering one with another, and were showing one to another the great and marvelous change which had taken place.

And they were also conversing about this Jesus Christ, of whom the sign had been given concerning his death.

And it came to pass that while they were thus conversing one with another, they heard a voice as if it came out of heaven; and they cast their eyes round about, for they understood not the voice which they heard; and it was not a harsh voice, neither was it a loud voice; nevertheless, and notwithstanding it being a small voice it did pierce them that did hear to the center, insomuch that there was no part of their frame that it did not cause to quake; yea, it did pierce them to the very soul, and did cause their hearts to burn.

And it came to pass that again they heard the voice, and they understood it not.

And again the third time they did hear the voice, and did open their ears to hear it; and their eyes were towards the sound thereof; and they did look steadfastly towards heaven, from whence the sound came.

And behold, the third time they did understand the voice which they heard; and it said unto them:

Behold my Beloved Son, in whom I am well pleased, in whom I have glorified my name—hear ye him.

- 8 Мөнхүү улиран тохиох дор, тэд ойлгоод тэнгэрийн зүг дахин хараа чиглүүлэв; мөн болгоогтун, тэд тэнгэрээс бууж ирж буй Хүнийг үзэв; мөн тэрээр цагаан орхимжоор хувцаслагдсан байв; мөн тэрээр бууж ирээд мөн тэдний дунд зогсов; мөн бүх цугларгсдын харц түүн дээр тусаж, мөн тэд бүр нэг нэгэндээ ч ам нээж зүрхэлсэнгүй, мөн энэ нь чухам ямар учиртайг мэдсэнгүй, учир нь тэдэнд үзэгдсэн нь тэнгэр элч хэмээн тэд боджээ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэр мутраа урагш сунгаад мөн хүмүүст ярьж, өгүүлсэн нь:
- 10 Болгоогтун, би бол дэлхийд ирэх болно хэмээн бошиглогчдын гэрчилсэн тэр Есүс Христ.
- 11 Мөн болгоогтун, би бол дэлхийн гэрэл ба амь; мөн би Эцэгийн надад өгсөн гашуун аяганаас ууж, мөн эхлэлээс бүх зүйлийн хувьд Эцэгийн тааллыг хүлцэж, дэлхийнхний нүглүүдийг өөр дээрээ авснаар Эцэгийг алдаршуулсан билээ.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгсийг ярьсны дараа бүх цугласан олон газарт унав; учир нь Христ тэнгэрт дээшлэн одсоныхоо дараа тэдэнд өөрийгөө үзүүлнэ гэсэн нь тэдний дунд бошиглогдсоныг тэд санацгаасан аж.
- 13 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн тэдэнд ярьж, хэлсэн нь:
- 14 Босогтун мөн хавирган талын сорвинд минь та нар гараа хүргэж болохын тулд, мөн түүнчлэн миний мутар дахь мөн хөлөн дэх хадаасны ормуудыг та нар тэмтэрч болохын тулд над дээр нааш ирэгтүн, тиймээс би бол Израилын Бурхан, мөн бүх дэлхийн Бурхан, мөн дэлхийнхний нүглүүдийн төлөө өгүүтгэгдсэнийг та нар мэдэж болно.
- 15 Мөнхүү улиран тохиох дор цугласан олон урагшилж, мөн гараа түүний хавирган талын сорвинд хүргэж, мөн түүний мутар дахь мөн түүний хөлөн дэх хадаасны ормуудыг тэмтэрч үзэв; мөн тэд үүнийг үйлдэж, бүгд очих хүртлээ нэг нэгээрээ явж, мөн нүдээрээ үзэж мөн гараараа тэмтэрч, мөн бошиглогчдоор ирэх болно хэмээн бичигдсэн тэр нь мөн болохыг гарцаагүйгээр мэдэж мөн гэрчлэв.

And it came to pass, as they understood they cast their eyes up again towards heaven; and behold, they saw a Man descending out of heaven; and he was clothed in a white robe; and he came down and stood in the midst of them; and the eyes of the whole multitude were turned upon him, and they durst not open their mouths, even one to another, and wist not what it meant, for they thought it was an angel that had appeared unto them.

And it came to pass that he stretched forth his hand and spake unto the people, saying:

Behold, I am Jesus Christ, whom the prophets testified shall come into the world.

And behold, I am the light and the life of the world; and I have drunk out of that bitter cup which the Father hath given me, and have glorified the Father in taking upon me the sins of the world, in the which I have suffered the will of the Father in all things from the beginning.

And it came to pass that when Jesus had spoken these words the whole multitude fell to the earth; for they remembered that it had been prophesied among them that Christ should show himself unto them after his ascension into heaven.

And it came to pass that the Lord spake unto them saying:

Arise and come forth unto me, that ye may thrust your hands into my side, and also that ye may feel the prints of the nails in my hands and in my feet, that ye may know that I am the God of Israel, and the God of the whole earth, and have been slain for the sins of the world.

And it came to pass that the multitude went forth, and thrust their hands into his side, and did feel the prints of the nails in his hands and in his feet; and this they did do, going forth one by one until they had all gone forth, and did see with their eyes and did feel with their hands, and did know of a surety and did bear record, that it was he, of whom it was written by the prophets, that should come.

16 Мөн тэд бүгд очоод мөн өөрсдөө үзэж, тэд нэгэн дуугаар хашгирч хэлсэн нь:

17 Хосанна! Бүхний Дээд Бурханы нэр алдаршиг! Мөн тэд Есүсийн хөлд доош унаж, мөн түүнийг шүтэн бишрэв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Нифайд ярьж (учир нь Нифай цугласан олны дунд байв) мөн тэрбээр түүнд хүрч ирэхийг зарлиг болов.

19 Мөн Нифай босож мөн очоод, мөн өөрийгөө Их Эзэний өмнө бөхийлгөн мөн түүний хөлийг үнсэв.

20 Мөн Их Эзэн түүнд босохыг зарлиг болов. Мөн тэрбээр босож мөн түүний өмнө зогсов.

21 Мөн Их Эзэн түүнд хэлэв: Намайг дахин тэнгэрт дээшлэн одоход энэ хүмүүст баптисм хүртээх хүчийг би чамд өгье.

22 Мөн дахин Их Эзэн бусад заримыг дуудаж, мөн тэдэнд нэгэн адилыг хэлжээ; мөн тэрбээр тэдэнд баптисм хүртээх хүчийг өгөв. Мөн тэрбээр тэдэнд хэлсэн нь: Энэхүү маягаар та нар баптисм хүртээх болно; мөн та нарын дунд ямар ч сөргөлдөөнүүд байх ёсгүй.

23 Та нарын үгсийн дагуу нүглүүдээ наманчилж, мөн миний нэрээр баптисм хүртэхийг хүсэх хэнд боловч, энэхүү маягаар та нар тэдэнд баптисм хүртээх болно гэдгийг үнэнээр би та нарт хэлнэ--Болгоогтун, та нар доош явж мөн усанд зогсох болно, мөн миний нэрээр тэдэнд та нар баптисм хүртээх болно.

24 Мөн эдүгээ болгоогтун, эдгээр нь та нарын хэлэх тэрхүү үгс, тэднийг нэрээр нь дуудаж хэлэх нь:

25 Есүс Христээр надад эрх мэдэл өгөгдсөн учир би Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнсний нэрээр танд баптисм хүртээж байна. Амен.

26 Мөн тэгээд та нар тэднийг усанд бүрэн дүрж, мөн уснаас буцаан гаргаж ирэх болно.

27 Мөн энэ маягийн дагуу миний нэрээр та нар баптисм хүртээх болно; учир нь болгоогтун, үнэнээр би та нарт хэлнэ, Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнс бол нэг юм; мөн би Эцэгт буй, мөн Эцэг надад буй, мөн Эцэг бид хоёр нэг юм.

And when they had all gone forth and had witnessed for themselves, they did cry out with one accord, saying:

Hosanna! Blessed be the name of the Most High God! And they did fall down at the feet of Jesus, and did worship him.

And it came to pass that he spake unto Nephi (for Nephi was among the multitude) and he commanded him that he should come forth.

And Nephi arose and went forth, and bowed himself before the Lord and did kiss his feet.

And the Lord commanded him that he should arise. And he arose and stood before him.

And the Lord said unto him: I give unto you power that ye shall baptize this people when I am again ascended into heaven.

And again the Lord called others, and said unto them likewise; and he gave unto them power to baptize. And he said unto them: On this wise shall ye baptize; and there shall be no disputations among you.

Verily I say unto you, that whoso repenteth of his sins through your words, and desireth to be baptized in my name, on this wise shall ye baptize them—Behold, ye shall go down and stand in the water, and in my name shall ye baptize them.

And now behold, these are the words which ye shall say, calling them by name, saying:

Having authority given me of Jesus Christ, I baptize you in the name of the Father, and of the Son, and of the Holy Ghost. Amen.

And then shall ye immerse them in the water, and come forth again out of the water.

And after this manner shall ye baptize in my name; for behold, verily I say unto you, that the Father, and the Son, and the Holy Ghost are one; and I am in the Father, and the Father in me, and the Father and I are one.

28 Мөн та нарт миний зарлиг болсны дагуу та нар  
тийн баптисм хүртээх болно. Мөн та нарын дунд өм-  
нө нь байсан шиг ямар ч сөргөлдөөн байх ёсгүй; бас  
өмнө нь байсан шиг сургаалын минь заалтуудын та-  
лаар та нарын дунд сөргөлдөөнүүд байх ёсгүй.

29 Учир нь үнэнээр, үнэнээр би та нарт хэлнэ, зөр-  
чилдөөний сүнстэй тэр нь надаас бус, харин зөрчил-  
дөөний эцэг болох чөтгөрөөс болой, мөн тэрбээр хү-  
мүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчил-  
дөхөд өдөөн хатгадаг.

30 Болгоогтун, хүмүүний зүрх сэтгэлийг нэг нь нө-  
гөөгийнхөө эсрэг уураар өдөөн хатгах нь миний сур-  
гаал бус; харин иймэрхүү зүйлүүд зайлуулагдах ёс-  
той нь миний сургаал бөлгөө.

31 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, би  
та нарт сургаалаа тунхаглах болно.

32 Мөн энэ бол миний сургаал, мөн энэ бол Эцэгийн  
надад өгсөн тэрхүү сургаал билээ; мөн би Эцэгийн  
тухай гэрчилж, мөн Эцэг миний тухай гэрчилж,  
мөн Ариун Сүнс нь Эцэг бид хоёрын тухай гэрчил-  
дэг; мөн наманчилж мөн надад итгэхийг Эцэг газар  
газрын бүх хүмүүст зарлиг болгодгийг би гэрчилж  
байна.

33 Мөн надад итгэсэн, мөн баптисм хүртсэн хэн бо-  
ловч, мөнхүү тэр нь аврагдах болно; мөн тэд бол  
Бурханы хаант улсыг өвлөх хүмүүс юм.

34 Мөн надад итгэхгүй, мөн баптисм хүртэхгүй хэн  
боловч, яллагдах болно.

35 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний  
сургаал, мөн Эцэгийн өмнөөс би үүнийг гэрчилнэ;  
мөн надад итгэдэг хэн боловч түүнчлэн Эцэгт итгэ-  
дэг; мөн түүнд миний тухай Эцэг гэрчилэх болно,  
учир нь тэрбээр түүнд галаар мөн Ариун Сүнсээр  
зочлох болно.

36 Мөн тийн Эцэг миний тухай гэрчилдэг, мөн  
Ариун Сүнс түүнд Эцэг бид хоёрын тухай гэрчлэх  
болно; учир нь Эцэг, мөн Би, мөн Ариун Сүнс бол  
нэг юм.

37 Мөн тэрчлэн би та нарт хэлнэ, та нар наманчилж,  
мөн бяцхан хүүхэд лугаа адил болж, мөн миний нэ-  
рээр баптисм хүртэх ёстой, эс бөгөөс та нар эдгээр  
зүйлийг ямар ч аргаар хүлээн авч чадахгүй.

And according as I have commanded you thus shall  
ye baptize. And there shall be no disputations among  
you, as there have hitherto been; neither shall there be  
disputations among you concerning the points of my  
doctrine, as there have hitherto been.

For verily, verily I say unto you, he that hath the spirit  
of contention is not of me, but is of the devil, who is the  
father of contention, and he stirreth up the hearts of  
men to contend with anger, one with another.

Behold, this is not my doctrine, to stir up the hearts  
of men with anger, one against another; but this is my  
doctrine, that such things should be done away.

Behold, verily, verily, I say unto you, I will declare  
unto you my doctrine.

And this is my doctrine, and it is the doctrine which  
the Father hath given unto me; and I bear record of the  
Father, and the Father beareth record of me, and the  
Holy Ghost beareth record of the Father and me; and I  
bear record that the Father commandeth all men, every-  
where, to repent and believe in me.

And whoso believeth in me, and is baptized, the same  
shall be saved; and they are they who shall inherit the  
kingdom of God.

And whoso believeth not in me, and is not baptized,  
shall be damned.

Verily, verily, I say unto you, that this is my doctrine,  
and I bear record of it from the Father; and whoso be-  
lieveth in me believeth in the Father also; and unto him  
will the Father bear record of me, for he will visit him  
with fire and with the Holy Ghost.

And thus will the Father bear record of me, and the  
Holy Ghost will bear record unto him of the Father and  
me; for the Father, and I, and the Holy Ghost are one.

And again I say unto you, ye must repent, and be-  
come as a little child, and be baptized in my name, or ye  
can in nowise receive these things.



38 Мөн тэрчлэн би та нарт хэлнэ, та нар наманчилж, мөн миний нэрээр баптисм хүртэж, мөн бяцхан хүүхэд лугаа адил болох ёстой, эс бөгөөс та нар Бурханы хаант улсыг ямар ч аргаар өвлөж чадахгүй.

39 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ нь миний сургаал, мөн үүний дээр барьж босгодог хэн боловч миний хадан дээр барьж босгоно, мөн тамын үүд тэднийг дийлэх нь үгүй.

40 Мөн эдүгээ үүнээс илүүг буюу дутууг тунхаглах мөн миний сургаал мэтээр түүнийг тогтоох хэн боловч, тэрхүү хүн хилэнцээс ирдэг, мөн миний хадан дээр барьж босгогдоогүй байдаг; харин тэр элсэн суурин дээр барьж босгодог мөн үер болж мөн тэдний дээр салхи нүдэхэд тиймийг нь хүлээн авахаар тамын хаалга нээлттэй байдаг.

41 Тиймийн тул, энэ хүмүүст очиж, мөн миний ярьсан үгсийг дэлхийн хязгааруудад тунхаглагтун.

And again I say unto you, ye must repent, and be baptized in my name, and become as a little child, or ye can in nowise inherit the kingdom of God.

Verily, verily, I say unto you, that this is my doctrine, and whoso buildeth upon this buildeth upon my rock, and the gates of hell shall not prevail against them.

And whoso shall declare more or less than this, and establish it for my doctrine, the same cometh of evil, and is not built upon my rock; but he buildeth upon a sandy foundation, and the gates of hell stand open to receive such when the floods come and the winds beat upon them.

Therefore, go forth unto this people, and declare the words which I have spoken, unto the ends of the earth.

### 3 Нифай 12

- 1 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг Нифайд, мөн дуудагдсан тэдэнд яриад, (эдүгээ дуудагдаж, мөн баптисм хүртээх хүч болон эрх мэдлийг хүлээн авсан тэдний тоо нь арванхоёр байв) мөн болгоогтун, тэр мутраа урагш цугларсан олонд сунгаж, мөн тэдэнд чанга дуугаар ярьж, өгүүлсэн нь: Та нарт тохинуулж, мөн та нарын зарц нар байхаар та нарын дундаас миний сонгосон эдгээр арван хоёрын үгсэд анхаарлаа хандуулах аваас та нар адислагдах болно; мөн тэд та нарт баптисм хүртээж болно хэмээн би хүчийг тэдэнд өгсөн бөлгөө; мөн та нар баптисм хүртсэний дараа, болгоогтун, би та нарт галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртээх болно; тиймийн тул та нар намайг харж мөн би байдаг гэдгийг мэдсэний дараа, та нар надад итгэж мөн баптисм хүртвэл адислагдах болно та нар.
- 2 Мөн тэрчлэн, та нар намайг харж, мөн би байдаг гэдгийг мэддэгээ та нар гэрчлэх учир, та нарын үгсэд итгэх тэд илүү адислагдах болно. Тийм ээ, үгсэд тань итгэх мөн даруу байдлын гүн уруу ирэх мөн баптисм хүртэх тэд адислагдах болно, учир нь тэд галаар мөн Ариун Сүнсээр зочлогдох болно, мөн нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авах болно.
- 3 Тийм ээ, надад ирэх сүнсэндээ ядуу нь адислагдах болно, учир нь тэнгэрийн хаант улс бол тэднийх юм.
- 4 Мөн тэрчлэн, гашуудах тэд бүгд адислагдах болно, учир нь тэд тайвшруулагдах болно.
- 5 Мөн хүлцэнгүй номхон нь адислагдах болно, учир нь тэд газар дэлхийг өвлөх болно.
- 6 Мөн зөв шударгын төлөө өлсөж мөн цангах тэд бүгд адислагдах болно, учир нь тэд Ариун Сүнсээр дүүргэгдэх болно.
- 7 Мөн нигүүлсэнгүй нь адислагдах болно, учир нь тэд өршөөл нигүүлслийг олж авах болно.
- 8 Мөн зүрх сэтгэлдээ цэвэр ариун бүгд нь адислагдах болно, учир нь тэд Бурханыг харна.
- 9 Мөн энхийг сахигч бүгд адислагдах болно, учир нь тэд Бурханы хүүхдүүд хэмээн нэрлэгдэх болно.
- 10 Мөн миний нэрийн төлөө хавчин гадуурхагдсан тэд бүгд адислагдах болно, учир нь тэнгэрийн хаант улс тэднийх юм.

### 3 Nephi 12

And it came to pass that when Jesus had spoken these words unto Nephi, and to those who had been called, (now the number of them who had been called, and received power and authority to baptize, was twelve) and behold, he stretched forth his hand unto the multitude, and cried unto them, saying: Blessed are ye if ye shall give heed unto the words of these twelve whom I have chosen from among you to minister unto you, and to be your servants; and unto them I have given power that they may baptize you with water; and after that ye are baptized with water, behold, I will baptize you with fire and with the Holy Ghost; therefore blessed are ye if ye shall believe in me and be baptized, after that ye have seen me and know that I am.

And again, more blessed are they who shall believe in your words because that ye shall testify that ye have seen me, and that ye know that I am. Yea, blessed are they who shall believe in your words, and come down into the depths of humility and be baptized, for they shall be visited with fire and with the Holy Ghost, and shall receive a remission of their sins.

Yea, blessed are the poor in spirit who come unto me, for theirs is the kingdom of heaven.

And again, blessed are all they that mourn, for they shall be comforted.

And blessed are the meek, for they shall inherit the earth.

And blessed are all they who do hunger and thirst after righteousness, for they shall be filled with the Holy Ghost.

And blessed are the merciful, for they shall obtain mercy.

And blessed are all the pure in heart, for they shall see God.

And blessed are all the peacemakers, for they shall be called the children of God.

And blessed are all they who are persecuted for my name's sake, for theirs is the kingdom of heaven.

11 Мөн надаас болж хүмүүс та нарыг доромжлох мөн хавчин гадуурхах мөн та нарын эсрэг гүтгэн бүхий л хилэнцгийг хэлэх үед та нар адислагдах болно.

12 Учир нь та нар агуу баясал мөн үлэмжийн баяр хөөртэй байх болно, учир нь тэнгэрт шагнал тань агуу байх болно; учир нь та нарын өмнө байсан бошиглогчдыг тэд тэгж хавчин үүнчлэн гадуурхсан билээ.

13 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, газар дэлхийн давс байх үүргийг би та нарт өгдөг; гэвч хэрэв давс амтаа алдвал газар дэлхий юугаар давслагдах билээ? Уг давс түүнээс хойш, зайлуулагдаж мөн хүмүүний хөл дор дэвслэгдэхээс өөр юунд ч хэрэггүй байх болно.

14 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ хүмүүсийн гэрэл байх үүргийг би та нарт өгнө. Толгойд дээр байрласан хот нууцлагдах аргагүй билээ.

15 Болгоогтун, хүмүүс лаа асаагаад мөн үүнийгээ тогтоон дор нуудаг бил үү? Үгүй ээ, харин лааны тавиур дээр тавьж, мөн энэ нь гэрт байгаа бүгдэд гэрэл өгдөг;

16 Тиймийн тул, тэд та нарын сайн ажлуудыг харж, тэгээд тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулж болохын тулд гэрэл тань энэ хүмүүсийн өмнө тийн туяаран гийг.

17 Хуулийг эсвээс бошиглогчдыг устгахаар намайг ирсэн гэж бүү бод. Би устгахаар ирсэн биш, харин гүйцэлдүүлэхээр билээ;

18 Учир нь үнэнээр би та нарт хэлнэ, уг хуулиас нэг цэг, нэг жижиг зураас ч улирч одоогүй, харин энэ нь бүгд надаар гүйцэлдсэн билээ.

19 Мөн болгоогтун, та нар надад итгэхийн тулд, мөн та нар нүглүүдээ наманчилж, мөн харууссан зүрх гэмшсэн сэтгэлтэйгээр надад ирэхийн тулд би Эцэгийнхээ хууль болон зарлигуудыг та нарт өгсөн. Болгоогтун, та нарын өмнө зарлигууд байна, мөн хууль нь гүйцэлдсэн билээ.

20 Тиймийн тул надад ирж мөн та нар аврагд; учир нь үнэнээр би та нарт хэлнэ, энэ цагт та нарт миний зарлигласан тэрхүү зарлигуудыг дагахаас бусдаар, та нар тэнгэрийн хаант улсад яавч орохгүй.

And blessed are ye when men shall revile you and persecute, and shall say all manner of evil against you falsely, for my sake;

For ye shall have great joy and be exceedingly glad, for great shall be your reward in heaven; for so persecuted they the prophets who were before you.

Verily, verily, I say unto you, I give unto you to be the salt of the earth; but if the salt shall lose its savor where-with shall the earth be salted? The salt shall be thenceforth good for nothing, but to be cast out and to be trodden under foot of men.

Verily, verily, I say unto you, I give unto you to be the light of this people. A city that is set on a hill cannot be hid.

Behold, do men light a candle and put it under a bushel? Nay, but on a candlestick, and it giveth light to all that are in the house;

Therefore let your light so shine before this people, that they may see your good works and glorify your Father who is in heaven.

Think not that I am come to destroy the law or the prophets. I am not come to destroy but to fulfil;

For verily I say unto you, one jot nor one tittle hath not passed away from the law, but in me it hath all been fulfilled.

And behold, I have given you the law and the commandments of my Father, that ye shall believe in me, and that ye shall repent of your sins, and come unto me with a broken heart and a contrite spirit. Behold, ye have the commandments before you, and the law is fulfilled.

Therefore come unto me and be ye saved; for verily I say unto you, that except ye shall keep my commandments, which I have commanded you at this time, ye shall in no case enter into the kingdom of heaven.

21 Энэ нь хуучин цагийн тэднээр хэлэгдсэнийг та нар сонссон, мөн энэ нь түүнчлэн та нарын өмнө бичигдсэн байна, чи алах ёсгүй, мөн алсан хэн боловч, Бурханы шүүлтийн дор аюултай байдалд байх болно;

22 Гэвч би та нарт хэлнэ, ахдаа уурласан хэн боловч түүний шүүлтийн дор аюултай байдалд байх болно. Мөн ах дүүдээ, Хоосон толгой гэж хэлэх хэн боловч, шүүхэд татагдах аюултай байдалд байх болно; мөн Чи мунхаг гэж хэлэх хэн боловч, галт тамын аюулд байх болно.

23 Тиймийн тул, хэрэв та нар надад ирэхийг өөрөөр хэлбэл надад ирэхийг хүсэвч мөн ах дүүд тань чиний эсрэг аливаа нэгэн буйг санах аваас—

24 Өөрийн замаар ах дүүдээ очиж, мөн эхлээд ах дүүтэйгээ эвлэрч, мөн тэгээд зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүллээр надад ирэгтүн, мөн би чамайг хүлээн авах болно.

25 Тэрээр чамайг ямар нэгэн үед дийлж, мөн чи шоронд хаягдах болуузай хэмээн өстөнтэйгээ замаар явж байхдаа түүнтэй хурдхан эвлэр.

26 Үнэнээр, үнэнээр, би чамд хэлнэ, чи эцсийн синайныг төлсөн байх хүртлээ тэндээс гарч ирэх аргагүй болно. Мөн та нар шоронд байх зуураа бүр ганц синайныг ч төлж чадна гэж үү? Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, Үгүй.

27 Болгоогтун, чи садар самууныг үйлдэх ёсгүй хэмээн хуучин цагийн тэднээр бичигдсэн байдаг;

28 Гэвч би та нарт хэлнэ, тачаадахын улмаас эмэгтэйг харсан хэн боловч, зүрх сэтгэлдээ аль хэдийн садар самууныг үйлдсэн байдаг.

29 Болгоогтун, та нар эдгээр зүйлийн нэгээхнийг ч зүрх сэтгэлдээ оруулахыг хүлцэх ёсгүй хэмээх зарлигийг би та нарт өгье;

30 Учир нь та нар өөрсдөө эдгээр зүйлсээс татгалзснаар та нар загалмайгаа үүрэх нь тамд хаягдсанаас дээр байх болно.

31 Эхнэрээсээ салсан хэн боловч, эхнэртээ салалтыг гэрчилсэн бичиг өг хэмээн бичигдсэн байдаг.

Ye have heard that it hath been said by them of old time, and it is also written before you, that thou shalt not kill, and whosoever shall kill shall be in danger of the judgment of God;

But I say unto you, that whosoever is angry with his brother shall be in danger of his judgment. And whosoever shall say to his brother, Raca, shall be in danger of the council; and whosoever shall say, Thou fool, shall be in danger of hell fire.

Therefore, if ye shall come unto me, or shall desire to come unto me, and rememberest that thy brother hath aught against thee—

Go thy way unto thy brother, and first be reconciled to thy brother, and then come unto me with full purpose of heart, and I will receive you.

Agree with thine adversary quickly while thou art in the way with him, lest at any time he shall get thee, and thou shalt be cast into prison.

Verily, verily, I say unto thee, thou shalt by no means come out thence until thou hast paid the uttermost sennine. And while ye are in prison can ye pay even one sennine? Verily, verily, I say unto you, Nay.

Behold, it is written by them of old time, that thou shalt not commit adultery;

But I say unto you, that whosoever looketh on a woman, to lust after her, hath committed adultery already in his heart.

Behold, I give unto you a commandment, that ye suffer none of these things to enter into your heart;

For it is better that ye should deny yourselves of these things, wherein ye will take up your cross, than that ye should be cast into hell.

It hath been written, that whosoever shall put away his wife, let him give her a writing of divorcement.

32 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, завхайрлын шалтгаанаас бусдаар эхнэрээсээ салах хэн боловч, түүнийг садар самууныг үйлдэх болгосон хэрэг юм; мөн салсан эхнэртэй гэрлэх хэн боловч садар самууныг үйлдсэн хэрэг юм.

33 Мөн тэрчлэн, чи хуурамчаар тангараглах ёсгүй нь бичигдсэн, харин Их Эзэний төлөөх ам тангаргаа биелүүлэх ёстой.

34 Гэвч үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, тангараг огт бүү тавь; бас тэнгэрээр ч бүү тангарагла, учир нь энэ бол Бурханы сэнтий юм;

35 Бас газар дэлхийгээр ч, учир нь энэ нь түүний хөлний гишгүүр бөлгөө;

36 Бас чи толгойгоороо ч бүү тангарагла, учир нь чи нэг үсийг ч хар эсвээс цагаан болгож чадахгүй;

37 Харин үг чинь Тийм ээ, тийм; Үгүй үгүй байг; учир нь эдгээрээс илүүгээр хэлэгдсэн нь юу боловч хилэнцэт бөлгөө.

38 Мөн болгоогтун, нүдийг нүдээр, мөн шүдийг шүдээр хэмээн бичигдсэн байдаг;

39 Харин би та нарт хэлнэ, та нар хилэнцэттэй бүү сөргөлд, харин баруун хацар дээр чинь хэн цохинов, түүнд нөгөө хацраа тавьж өг;

40 Мөн хэн нэгэн чамтай хуулиар заалдаж мөн хүрмийг тань авбал, түүнд орхимжоо ч түүнчлэн өг;

41 Мөн хэн нэгэн чамайг нэг бээр явахыг албадвал, түүнтэй хоёр бээр явагтун.

42 Чамаас гуйсанд өг, мөн чамаас зээлэх гэсэн түүнд чи бүү араа харуул.

43 Мөн болгоогтун түүнчлэн, чи хөршөө хайрлаж мөн дайснаа үзэн яд гэж бичигдсэн байдаг;

44 Гэвч болгоогтун би та нарт хэлнэ, дайснуудаа хайрла, чамайг зүхэх тэднийг адисал, чамайг үзэн ядах тэдэнд сайныг үйлд, мөн чамайг хүнлэг бусаар ашиглах мөн чамайг хавчин гадуурхах тэдний төлөө залбир;

45 Та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд байж болохын тулд буюу; учир нь тэрбээр өөрийн нарыг хилэнцтийн дээр мөн сайны дээр мандах болгодог.

46 Тиймийн тул эрт цагийн тэдгээр зүйл, хуулийн харьяат байсан тэр нь, надаар бүгд гүйцэлдсэн билээ.

Verily, verily, I say unto you, that whosoever shall put away his wife, saving for the cause of fornication, causeth her to commit adultery; and whoso shall marry her who is divorced committeth adultery.

And again it is written, thou shalt not forswear thyself, but shalt perform unto the Lord thine oaths;

But verily, verily, I say unto you, swear not at all; neither by heaven, for it is God's throne;

Nor by the earth, for it is his footstool;

Neither shalt thou swear by thy head, because thou canst not make one hair black or white;

But let your communication be Yea, yea; Nay, nay; for whatsoever cometh of more than these is evil.

And behold, it is written, an eye for an eye, and a tooth for a tooth;

But I say unto you, that ye shall not resist evil, but whosoever shall smite thee on thy right cheek, turn to him the other also;

And if any man will sue thee at the law and take away thy coat, let him have thy cloak also;

And whosoever shall compel thee to go a mile, go with him twain.

Give to him that asketh thee, and from him that would borrow of thee turn thou not away.

And behold it is written also, that thou shalt love thy neighbor and hate thine enemy;

But behold I say unto you, love your enemies, bless them that curse you, do good to them that hate you, and pray for them who despitefully use you and persecute you;

That ye may be the children of your Father who is in heaven; for he maketh his sun to rise on the evil and on the good.

Therefore those things which were of old time, which were under the law, in me are all fulfilled.

47 Хуучин зүйлүүд төгсөж, мөн бүх зүйл шинэ бол-  
лоо.

48 Тиймийн тул би, эсвээс тэнгэрт буй Эцэг тань төг-  
сийн адил та нарыг төгс байгаасай хэмээнэ би.

Old things are done away, and all things have become  
new.

Therefore I would that ye should be perfect even as I,  
or your Father who is in heaven is perfect.

### 3 Нифай 13

- 1 Үнэнээр, үнэнээр, би хэлнэ та нар ядууд өглөг үйлдээсэй хэмээнэ би; харин тэдэнд харагдахын тулд хүмүүний өмнө өглөгөө үйлдэхгүй байхыг анхаар; эс бөгөөс тэнгэр дэх Эцэгээс тань та нарт шагнал үгүй бөлгөө.
- 2 Тиймийн тул тэд хүмүүнийг алдар нэрийг олж болохын тулд, синагогт мөн гудамжинд хоёр нүүртнүүдийн үйлддэг шиг та нар өглөг үйлдэхдээ өөрсдийнхөө өмнө бүрээ бүү тат. Үнэнээр би та нарт хэлнэ, тэд шагналаа авсан билээ.
- 3 Харин чи өглөг үйлдэхдээ баруун гарынхаа юу хийж байгааг зүүн гартаа бүү мэдүүл;
- 4 Чиний өглөгүүд нууц байж болохын тулд буюу; мөн нууцыг хардаг Эцэг тань, өөрөө чамайг илээр шагнах болно.
- 5 Мөн чи залбирахдаа хоёр нүүртнүүд шиг үйлдэж болохгүй, учир нь тэд хүмүүнд харагдаж болохын тулд тэд синагогуудад мөн гудамжны буланд зогсон залбирах дуртай. Үнэнээр би та нарт хэлнэ, тэд шагналаа авсан билээ.
- 6 Харин чи, чи залбирахдаа, гонхондоо орж, мөн хаалгаа хаагаад, нууцад байх Эцэгтээ залбир; мөн нууцыг харах Эцэг тань, чамайг илээр шагнах болно.
- 7 Харин та нар залбирахдаа, буруу номтнууд шиг хоосон давталт бүү хэрэглэ, учир нь тэд ихийг яривал сонсогдох болно хэмээн боддог.
- 8 Та нар тиймийн тул тэдэнтэй адил бүү бай, учир нь та нарт юу хэрэгтэй байгааг түүнээс гуйхаас чинь өмнө Эцэг тань мэддэг юм.
- 9 Тиймийн тул та нар энэ маягаар залбир: Тэнгэрт буй Эцэг минь, нэр тань ариусан алдаршиг.
- 10 Таны таалал тэнгэрт гүйцэлддэг шигээ газар дээр ч тэгэх болтугай.
- 11 Мөн бид өртнүүдээ уучлахын хэрээр, бидний өрийг өршөөгөөч.
- 12 Мөн биднийг уруу таталтын зүг бүү дагуулаач, харин биднийг хилэнцээс чөлөөлөөч.
- 13 Учир нь хаант улс, мөн хүч, мөн алдар суу, үүрд таных. Амен.

### 3 Nephi 13

Verily, verily, I say that I would that ye should do alms unto the poor; but take heed that ye do not your alms before men to be seen of them; otherwise ye have no reward of your Father who is in heaven.

Therefore, when ye shall do your alms do not sound a trumpet before you, as will hypocrites do in the synagogues and in the streets, that they may have glory of men. Verily I say unto you, they have their reward.

But when thou doest alms let not thy left hand know what thy right hand doeth;

That thine alms may be in secret; and thy Father who seeth in secret, himself shall reward thee openly.

And when thou prayest thou shalt not do as the hypocrites, for they love to pray, standing in the synagogues and in the corners of the streets, that they may be seen of men. Verily I say unto you, they have their reward.

But thou, when thou prayest, enter into thy closet, and when thou hast shut thy door, pray to thy Father who is in secret; and thy Father, who seeth in secret, shall reward thee openly.

But when ye pray, use not vain repetitions, as the heathen, for they think that they shall be heard for their much speaking.

Be not ye therefore like unto them, for your Father knoweth what things ye have need of before ye ask him.

After this manner therefore pray ye: Our Father who art in heaven, hallowed be thy name.

Thy will be done on earth as it is in heaven.

And forgive us our debts, as we forgive our debtors.

And lead us not into temptation, but deliver us from evil.

For thine is the kingdom, and the power, and the glory, forever. Amen.

14 Учир нь, хэрэв та нар хүмүүнийг алдаануудынх нь учир уучлах аваас тэнгэрлэг Эцэг тань түүнчлэн та нарыг өршөөх болно;

15 Харин хэрэв та нар хүмүүнийг алдаануудынх нь төлөө уучлахгүй бол Эцэг тань ч та нарын алдаануудыг өршөөх нь үгүй.

16 Цаашилбал, та нар мацаг барихдаа, хоёр нүүртнүүд шиг гунигтай төрх бүү гарга, учир нь тэд мацаг барьж буйгаа хүмүүнд харуулж болохын тулд царайгаа барайлгадаг. Үнэнээр би та нарт хэлнэ, тэд шагналаа авсан юм.

17 Харин чи, мацаг барихдаа, толгойдоо тос түрхэж, мөн нүүрээ угаа;

18 Чи мацаг барьж буйгаа хүмүүнд бус, харин нууцад байх Эцэгтээ харуулахын тулд болой; мөн нууцыг харах Эцэг тань чамайг илээр шагнах болно.

19 Өөрсөддөө газар дэлхий дээр баялаг бүү хураа, тэнд цагаан эрвээхий мөн зэв идэж мөн хулгайч нар эвдэн ороод мөн хулгайлдаг;

20 Харин өөрсөддөө тэнгэрт баялаг хураа, тэнд цагаан эрвээхий мөн зэв идэхгүй мөн хулгайч нар эвдэн орж бас хулгайлах нь үгүй.

21 Учир нь баялаг тань хаана байна, тэнд зүрх сэтгэл тань түүнчлэн байдаг.

22 Биеийн гэрэл нь нүд ажгуу, тиймийн тул, хэрэв нүд чинь нэгэн чигт байх аваас, бүхэл бие чинь гэрлээр дүүрэн байх болно.

23 Харин нүд чинь хилэнцэт аваас бүхэл бие чинь харанхуйгаар дүүрэн байх болно. Тиймийн тул, хэрэв чамд байх гэрэл нь харанхуй аваас, тэрхүү харанхуй нь хичнээн агуу байх билээ!

24 Нэг ч хүн хоёр эзэнд зэрэг үйлчилж чадахгүй; учир нь тэр нэгийг нь үзэн ядаж мөн нөгөөг нь хайрлах болно, эсвэл тэр нэгэнд нь үнэнч байж мөн нөгөөг нь зэвүүцэх болно. Та нар Бурханд бас Эд хөрөнгөнд зэрэг үйлчилж чадахгүй.

For, if ye forgive men their trespasses your heavenly Father will also forgive you;

But if ye forgive not men their trespasses neither will your Father forgive your trespasses.

Moreover, when ye fast be not as the hypocrites, of a sad countenance, for they disfigure their faces that they may appear unto men to fast. Verily I say unto you, they have their reward.

But thou, when thou fastest, anoint thy head, and wash thy face;

That thou appear not unto men to fast, but unto thy Father, who is in secret; and thy Father, who seeth in secret, shall reward thee openly.

Lay not up for yourselves treasures upon earth, where moth and rust doth corrupt, and thieves break through and steal;

But lay up for yourselves treasures in heaven, where neither moth nor rust doth corrupt, and where thieves do not break through nor steal.

For where your treasure is, there will your heart be also.

The light of the body is the eye; if, therefore, thine eye be single, thy whole body shall be full of light.

But if thine eye be evil, thy whole body shall be full of darkness. If, therefore, the light that is in thee be darkness, how great is that darkness!

No man can serve two masters; for either he will hate the one and love the other, or else he will hold to the one and despise the other. Ye cannot serve God and Mammon.



25 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад өөрийн сонгосон арван хоёрыг харж, мөн тэдэнд хэлэв: Миний ярьсан үгсийг сана. Учир нь болгоогтун, та нар энэ хүмүүст тохинуулахаар миний сонгосон тэд билээ. Тиймийн тул би та нарт хэлнэ, аминыхаа төлөө, та нар юу идэх, эсвээс юу уухав; бас биеийнхээ төлөө, юу өмсөхөв хэмээн санаа тавих хэрэггүй. Амь нь махнаас илүү, бие нь хувцаснаас илүү бус уу

26 Агаар дахь жигүүртнүүдийг болгоогтун, учир нь тэд тариалдаггүй, бас хадаж бас хороонд хураадаггүй; гэсэн ч тэнгэрлэг Эцэг тань тэднийг тэжээдэг. Та нар тэдгээрээс хавьгүй илүү бус уу

27 Та нарын хэн нь санаа тавьснаараа биеийнхээ өндрийг нэг тохой нэмэгдүүлж чадах билээ

28 Мөн та нар юуны учир хувцас хунарын төлөө санаа тавих билээ? Талбай дахь сараана цэцгүүд хэрхэн ургадгийг бодож үз; тэд хөдөлмөрлөдөггүй, бас ээрдэг ч үгүй;

29 Мөн гэвч би та нарт хэлнэ, бүр Соломон алдрынхаа оргилд байхдаа ч, эдгээрийн нэгэнтэй нь ч адил хувцаслаж байгаагүй юм.

30 Иймийн тул, хэрэв Бурхан, өнөөдөр байгаа мөн маргааш нь зууханд хаягдах талын өвсийг ийн хувцасласан бол, үүнчлэн тэрбээр та нарыг хувцаслах болно, хэрэв та нар бага итгэлтэй бус аваас.

31 Тиймийн тул, Бид юу идэх билээ? эсвээс, Бид юу уух билээ? эсвээс, Бид юугаар хувцаслах билээ? хэмээн бүү санаа зов.

32 Учир нь тэнгэрлэг Эцэг тань та нарт эдгээр бүх зүйл хэрэгтэйг мэддэг.

33 Харин та нар эхлээд Бурханы хаант улсыг мөн түүний зөв шударгыг эрэлхийл, мөн эдгээр бүх зүйл та нарт нэмэгдэн өгөгдөх болно.

34 Тиймийн тул маргаашийн төлөө санаа бүү тавь, учир нь маргааш нь өөрөө өөрийнхөө зүйлүүдэд санаа тавих болно. Тухайн өдрийн хилэнц нь тэр өдөртөө хангалттай билээ.

And now it came to pass that when Jesus had spoken these words he looked upon the twelve whom he had chosen, and said unto them: Remember the words which I have spoken. For behold, ye are they whom I have chosen to minister unto this people. Therefore I say unto you, take no thought for your life, what ye shall eat, or what ye shall drink; nor yet for your body, what ye shall put on. Is not the life more than meat, and the body than raiment?

Behold the fowls of the air, for they sow not, neither do they reap nor gather into barns; yet your heavenly Father feedeth them. Are ye not much better than they?

Which of you by taking thought can add one cubit unto his stature?

And why take ye thought for raiment? Consider the lilies of the field how they grow; they toil not, neither do they spin;

And yet I say unto you, that even Solomon, in all his glory, was not arrayed like one of these.

Wherefore, if God so clothe the grass of the field, which today is, and tomorrow is cast into the oven, even so will he clothe you, if ye are not of little faith.

Therefore take no thought, saying, What shall we eat? or, What shall we drink? or, Wherewithal shall we be clothed?

For your heavenly Father knoweth that ye have need of all these things.

But seek ye first the kingdom of God and his righteousness, and all these things shall be added unto you.

Take therefore no thought for the morrow, for the morrow shall take thought for the things of itself. Sufficient is the day unto the evil thereof.

### 3 Нифай 14

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад цугласан олонд тэрээр дахин хандаж, мөн тэдний зүг дахин ам нээж, хэлсэн нь: Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, Бүү шүүгтүн, та нар шүүгдэхгүйн тулд болой.
- 2 Учир нь та нар ямар шүүлтээр шүүнэ, та нар түүгээрээ шүүгдэх болно; мөн та нар ямар хэмжээгээр хэмжинэ, та нар тэрчлэн хэмжигдэх болно.
- 3 Мөн чи яагаад ах дүүгийнхээ нүдэн дэх үртсийг болгоодог хэрнээ өөрийнхөө нүдэн дэх дүнзийг анзаардаггүй билээ
- 4 Эс бөгөөс чи ах дүүдээ: Нүдэн дэх үртсийг чинь аваад өгье хэмээн— мөн болгоогтун, өөрийн тань нүдэнд дүнз байхад хэрхэн хэлэх билээ
- 5 Хоёр нүүртэн чи, эхлээд өөрийнхөө нүднээс дүнзийг гаргаж хая; мөн тэгээд чи ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхаа сайн харах болно.
- 6 Ариун болох түүнийг ноходод бүү өг, бас гахайн өмнө сувдаа бүү хая, тэд тэдгээрийг хөл дороо дэвслээд, мөн эргэж бас чамайг урах болуузай.
- 7 Гуй, тэгвэл энэ нь та нарт өгөгдөх болно; эрэлхийл, тэгвэл та нар олох болно; тогш тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно.
- 8 Учир нь гуйсан болгон хүлээн авдаг; мөн эрэлхийлэх тэр нь, олддог; мөн тогшсон түүнд энэ нь нээгдэх болно.
- 9 Эсвэл та нарын хэн нь, хүүгээ талх гуйхад, түүнд чулуу өгөх билээ
- 10 Эсвэл түүнийг загас гуйхад, тэр түүнд могой өгөх бил үү
- 11 Хэрэв тэгээд та нар, хилэнцэт байж, хүүхдүүддээ хэрхэн сайн бэлэг өгөхийг мэддэг бол, тэнгэр дэх Эцэг тань түүнээс гуйсан тэдэнд сайн зүйлийг хичнээн ихээр өгөх билээ
- 12 Тиймийн тул, хүмүүн өөрсдөд тань хэрхэн хандахыг хүсдэгчлэн юуг боловч, бүх зүйлийг, та нар тэдэнд түүнчлэн үйлд, учир нь энэ бол хууль хийгээд бошиглогчид билээ.
- 13 Та нар давчуу хаалгаар орогтун; учир нь устгалд хөтлөх тэр зам уужим, мөн хаалга нь өргөн, мөн түүгээр ордог нь олон байдаг.

### 3 Nephi 14

And now it came to pass that when Jesus had spoken these words he turned again to the multitude, and did open his mouth unto them again, saying: Verily, verily, I say unto you, Judge not, that ye be not judged.

For with what judgment ye judge, ye shall be judged; and with what measure ye mete, it shall be measured to you again.

And why beholdest thou the mote that is in thy brother's eye, but considerest not the beam that is in thine own eye?

Or how wilt thou say to thy brother: Let me pull the mote out of thine eye—and behold, a beam is in thine own eye?

Thou hypocrite, first cast the beam out of thine own eye; and then shalt thou see clearly to cast the mote out of thy brother's eye.

Give not that which is holy unto the dogs, neither cast ye your pearls before swine, lest they trample them under their feet, and turn again and rend you.

Ask, and it shall be given unto you; seek, and ye shall find; knock, and it shall be opened unto you.

For every one that asketh, receiveth; and he that seeketh, findeth; and to him that knocketh, it shall be opened.

Or what man is there of you, who, if his son ask bread, will give him a stone?

Or if he ask a fish, will he give him a serpent?

If ye then, being evil, know how to give good gifts unto your children, how much more shall your Father who is in heaven give good things to them that ask him?

Therefore, all things whatsoever ye would that men should do to you, do ye even so to them, for this is the law and the prophets.

Enter ye in at the strait gate; for wide is the gate, and broad is the way, which leadeth to destruction, and many there be who go in thereat;

14 Учир юун гэвэл амьдралд удирдах тэр хаалга давчуу, мөн зам нь нарийн, мөн үүнийг олдог нь цөөхөн байдаг.

15 Хонины арьс нөмрөн та нарт ирэх, хуурамч бошиглогчдоос сэрэмжил, харин дотор нь улангассан чононууд байдаг.

16 Та нар тэднийг үр жимсээр нь таних болно. Хүмүүн өргөснөөс усан үзэм, эсвээс халгайнаас инжир хураадаг гэж үү

17 Үүнчлэн сайн мод болгон сайн жимс өгдөг; харин ялзарсан мод хилэнцэт үр жимс өгдөг.

18 Сайн мод хилэнцэт үр жимс өгч, бас ялзарсан мод ч сайн үр жимс өгч чадахгүй.

19 Сайн үр жимс өгдөггүй мод болгон тас цавчигдаж, мөн галд хаягддаг.

20 Иймийн тул, үр жимсээр нь та нар тэднийг таних болно.

21 Их Эзэн минь, Их Эзэн минь гэж надад хэлдэг болгон тэнгэрийн хаант улсад орохгүй; харин тэнгэр дэх Эцэгийн минь тааллыг биелүүлдэг тэр нь бөлгөө.

22 Олон нь тэр өдөр надад хэлэх болно: Их Эзэн, Их Эзэн, бид таны нэрээр бошиглож мөн таны нэрээр чөтгөрүүдийг зайлуулж, мөн таны нэрээр олон гайхамшигт ажлыг үйлдээгүй гэж үү

23 Мөн тэгэхэд би тэдэнд өгүүлнэ: Би та нарыг огт танихгүй; алдсыг үйлдэгч та нар надаас холд.

24 Тиймийн тул, эдгээр үгсийг минь сонсоод, тэдгээрийг биелүүлэх хэнийг боловч, түүнийг хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй би адилтгах болно—

25 Мөн бороо орж, бас үер бууж, тэгээд салхи үлээж, мөнхүү байшинг нүдэв; мөн энэ нь унасангүй, учир нь хадан дээр суурилсан байв.

26 Мөн эдгээр үгийг минь сонсоод, мөн тэдгээрийг үл биелүүлдэг болгон, элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй адилтгагдах болно—

27 Мөн бороо орж, бас үер бууж, тэгээд салхи үлээж, мөнхүү байшинг нүдэв; мөн энэ нь унасан байв, мөн уналт нь агуу байлаа.

Because strait is the gate, and narrow is the way, which leadeth unto life, and few there be that find it.

Beware of false prophets, who come to you in sheep's clothing, but inwardly they are ravening wolves.

Ye shall know them by their fruits. Do men gather grapes of thorns, or figs of thistles?

Even so every good tree bringeth forth good fruit; but a corrupt tree bringeth forth evil fruit.

A good tree cannot bring forth evil fruit, neither a corrupt tree bring forth good fruit.

Every tree that bringeth not forth good fruit is hewn down, and cast into the fire.

Wherefore, by their fruits ye shall know them.

Not every one that saith unto me, Lord, Lord, shall enter into the kingdom of heaven; but he that doeth the will of my Father who is in heaven.

Many will say to me in that day: Lord, Lord, have we not prophesied in thy name, and in thy name have cast out devils, and in thy name done many wonderful works?

And then will I profess unto them: I never knew you; depart from me, ye that work iniquity.

Therefore, whoso heareth these sayings of mine and doeth them, I will liken him unto a wise man, who built his house upon a rock—

And the rain descended, and the floods came, and the winds blew, and beat upon that house; and it fell not, for it was founded upon a rock.

And every one that heareth these sayings of mine and doeth them not shall be likened unto a foolish man, who built his house upon the sand—

And the rain descended, and the floods came, and the winds blew, and beat upon that house; and it fell, and great was the fall of it.

### 3 Нифай 15

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгээ төгсгөөд тэрбээр цугласан олны зүг хараа бэлчээн, мөн тэдэнд хэлэв: Болгоогтун, намайг Эцэгтээ дээш одоохоос өмнө миний заасан зүйлүүдийг та нар сонслоо; тиймийн тул, миний эдгээр үгийг санаж мөн эдгээрийг биелүүлэх хэнийг боловч, түүнийг би эцсийн өдөр өргөмжлөх болно.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг хэлээд Мосегийн хуулийн талаар өөрийг нь юу хүсч буй бол хэмээн гайхширч мөн гайхсан зарим нь тэдний дунд буйг ухаарав; учир нь хуучин зүйлүүд улирч одоод, мөн бүх зүйл шинэ болсон гэснийг тэд ойлгосонгүй.
- 3 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Хуучин зүйлүүд улирч одоод, мөн бүх зүйл шинэ болсон гэж би та нарт хэлсэнд бүү гайх.
- 4 Болгоогтун, Мосед өгөгдсөн хууль гүйцэлдсэнийг би та нарт хэлнэ.
- 5 Болгоогтун, би бол хуулийг өгсөн тэр билээ, мөн би бол Израил дахь өөрийн хүмүүстэй гэрээ хийсэн тэр билээ; тиймийн тул, хууль нь надаар гүйцэлдсэн, учир нь би уг хуулийг гүйцэлдүүлэхээр ирсэн; тиймийн тул энэ нь төгсгөл болов.
- 6 Болгоогтун, би бошиглогчдыг устгадаггүй, учир нь надаар гүйцэлдээгүй болгон нь, үнэнээр би та нарт хэлнэ, бүгд гүйцэлдэх болно.
- 7 Мөн би та нарт хуучин зүйлүүд улирч одсон хэмээн хэлсэн учраас, ирэх тэр зүйлүүдийн талаар яригдсан тэрнийг би устгахгүй.
- 8 Учир нь болгоогтун, өөрийн хүмүүстэй хийсэн миний гэрээ бүгд гүйцэлдээгүй; гэвч Мосед өгөгдсөн хууль надаар төгсгөл болсон бөлгөө.
- 9 Болгоогтун, би бол хууль, мөн гэрэл. Надад хандагтун, мөн эцсээ хүртэл тэвчигтүн, мөн та нар амьдрах болно; учир нь эцсээ хүртэл тэвчсэн түүнд би мөнх амьдрал өгөх болно.
- 10 Болгоогтун, би та нарт зарлигууд өгсөн билээ; тиймийн тул зарлигуудыг минь дага. Мөн энэ бол хууль хийгээд бошиглогчид, учир нь тэд үнэхээр миний тухай гэрчилсэн юм.

### 3 Nephi 15

And now it came to pass that when Jesus had ended these sayings he cast his eyes round about on the multitude, and said unto them: Behold, ye have heard the things which I taught before I ascended to my Father; therefore, whoso remembereth these sayings of mine and doeth them, him will I raise up at the last day.

And it came to pass that when Jesus had said these words he perceived that there were some among them who marveled, and wondered what he would concerning the law of Moses; for they understood not the saying that old things had passed away, and that all things had become new.

And he said unto them: Marvel not that I said unto you that old things had passed away, and that all things had become new.

Behold, I say unto you that the law is fulfilled that was given unto Moses.

Behold, I am he that gave the law, and I am he who covenanted with my people Israel; therefore, the law in me is fulfilled, for I have come to fulfil the law; therefore it hath an end.

Behold, I do not destroy the prophets, for as many as have not been fulfilled in me, verily I say unto you, shall all be fulfilled.

And because I said unto you that old things have passed away, I do not destroy that which hath been spoken concerning things which are to come.

For behold, the covenant which I have made with my people is not all fulfilled; but the law which was given unto Moses hath an end in me.

Behold, I am the law, and the light. Look unto me, and endure to the end, and ye shall live; for unto him that endureth to the end will I give eternal life.

Behold, I have given unto you the commandments; therefore keep my commandments. And this is the law and the prophets, for they truly testified of me.

11 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад, тэрбээр өөрийн сонгосон арван хоёрт хэлэв:

12 Та нар миний шавь нар; мөн та нар Иосефын угсааны үлдэгдэл болох энэ хүмүүст гэрэл билээ.

13 Мөн болгоогтун, энэ бол та нарын өвлөсөн нутаг; мөн Эцэг үүнийг та нарт өгсөн бөлгөө.

14 Иерусалим дахь ах дүүст тань үүнийг хэл хэмээх зарлигийг Эцэг надад хэзээ ч өгч байгаагүй.

15 Басхүү Эцэг нутгаас нь гарган удирдсан, Израилын угсааны бусад овгуудын талаар намайг тэдэнд хэл хэмээх зарлигийг Эцэг хэзээ ч надад өгч байгаагүй.

16 Эцэгийн надад зарлигласнаар, өдий зэргийг би тэдэнд хэлэх ёстой:

17 Энэ хорооных бус өөр хонинууд надад бий; би тэднийг түүнчлэн авчрах ёстой, мөн тэд дуу хоолойг минь сонсох болно; мөн нэг хороо, мөн нэг хоньчин байх болно.

18 Мөн эдүгээ, гэжүүд мөн итгэлгүйн учир миний үгийг тэд ойлгосонгүй; тиймийн тул энэ зүйлийн талаар тэдэнд илүүг ярихгүй байхыг би Эцэгээр зарлиг болгогдсон билээ.

19 Гэвч, үнэнээр, би та нарт хэлнэ, Эцэг надад зарлиг болгож, мөн би үүнийг та нарт хэлнэ, та нар тэдний дундаас алдсуудынх нь учир тусгаарлагдсан; тиймийн тул тэд та нарын тухай мэддэггүй нь тэдний алдсын учир билээ.

20 Мөн бусад овгуудыг Эцэг тэднээс тусгаарласныг үнэнээр би та нарт тэрчлэн хэлье; мөн тэдний тухай тэд мэддэггүй нь өөрсдийнх нь алдсын улмаас болой.

21 Мөн үнэнээр би та нарт хэлнэ, та нар бол миний тухайлан хэлсэн тэд билээ: энэ хорооных бус өөр хонинууд надад бий; би тэднийг түүнчлэн авчрах ёстой, мөн тэд дуу хоолойг минь сонсох болно; мөн нэг хороо, мөн нэг хоньчин байх болно.

22 Мөн тэд намайг ойлгосонгүй, учир нь энэ бол харийнхан хэмээн тэд бодсон аж; учир нь харийнхан өөрсдийнх нь номлолоор дамжин хөрвүүлэгдэх болно гэдгийг тэд ойлгоогүй ажээ.

And now it came to pass that when Jesus had spoken these words, he said unto those twelve whom he had chosen:

Ye are my disciples; and ye are a light unto this people, who are a remnant of the house of Joseph.

And behold, this is the land of your inheritance; and the Father hath given it unto you.

And not at any time hath the Father given me commandment that I should tell it unto your brethren at Jerusalem.

Neither at any time hath the Father given me commandment that I should tell unto them concerning the other tribes of the house of Israel, whom the Father hath led away out of the land.

This much did the Father command me, that I should tell unto them:

That other sheep I have which are not of this fold; them also I must bring, and they shall hear my voice; and there shall be one fold, and one shepherd.

And now, because of stiffneckedness and unbelief they understood not my word; therefore I was commanded to say no more of the Father concerning this thing unto them.

But, verily, I say unto you that the Father hath commanded me, and I tell it unto you, that ye were separated from among them because of their iniquity; therefore it is because of their iniquity that they know not of you.

And verily, I say unto you again that the other tribes hath the Father separated from them; and it is because of their iniquity that they know not of them.

And verily I say unto you, that ye are they of whom I said: Other sheep I have which are not of this fold; them also I must bring, and they shall hear my voice; and there shall be one fold, and one shepherd.

And they understood me not, for they supposed it had been the Gentiles; for they understood not that the Gentiles should be converted through their preaching.

23 Мөн тэд дуу хоолойг минь сонсох болно гэж би хэлснийг тэд ойлгоогүй байв; мөн харийнхан хэзээ ч миний дуу хоолойг сонсохгүй гэхэд тэд намайг ойлгосонгүй—Ариун Сүнсээр бус аваас би өөрийгөө тэдэнд үзүүлэхгүй гэдгийг болой.

24 Гэвч болгоогтун, та нар аль аль нь миний дуу хоолойг сонссон, мөн намайг харсан; мөн та нар миний хоньд, мөн та нар надад Эцэгийн өгсөн тэдний дунд тоологддог билээ.

And they understood me not that I said they shall hear my voice; and they understood me not that the Gentiles should not at any time hear my voice—that I should not manifest myself unto them save it were by the Holy Ghost.

But behold, ye have both heard my voice, and seen me; and ye are my sheep, and ye are numbered among those whom the Father hath given me.

### 3 Нифай 16

- 1 Мөн үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ энэ нутагт бас Иерусалимын нутагт ч, бас миний тохинуулсан тэндхийн эргэн тойрны нутгийн аль ч хэсэгт байхгүй өөр хонинууд надад бий.
- 2 Учир нь миний тухайлан ярьж байгаа тэд дуу хоолойг минь харахан сонсоогүй тэд билээ; бас би тэдэнд өөрийгөө огт үзүүлээгүй байгаа.
- 3 Гэвч нэг хороо байж мөн нэг хоньчинтой байж болохын тулд намайг тэдэнд очиж, мөн тэд дуу хоолойг минь сонсож, мөн хонинуудын минь дунд тоологдох болно гэсэн зарлигийг би Эцэгээс хүлээн авсан; тиймийн тул өөрийгөө тэдэнд үзүүлэхээр би явна.
- 4 Мөн хэрэв намайг харсан мөн надтай хамт тохинуулалд минь байсан Иерусалим дахь миний хүмүүс та нарын тухай, мөн түүнчлэн тэд тухайлан мэдэхгүй бусад овгуудын тухай мэдлэгийг Ариун Сүнсээр хүлээн авч болохын тулд миний нэрээр Эцэгээс асуухгүй аваас, итгэлгүйнхээ учир газрын гадаргуу дээр тараагдах тэдний үр удмын үлдэгдэл нь, харийнханы бүрэн байдлаар дамжуулан, дотогш авчрагдаж болно, өөрөөр хэлбэл тэдний Гэтэлгэгч болох миний тухай мэдлэгт авчрагдаж болохын тулд та нарын бичих эдгээр үгс харийнханд хадгалагдаж мөн үзүүлэгдэхийн тулд намайг явсны дараа эдгээр үгийг та нар бичихийг би та нарт зарлиг болгож байна.
- 5 Мөн тэгээд би тэднийг газар дэлхийн дөрвөн зүгээс цуглуулах болно; мөн тэгээд Израилын угсааны бүх хүмүүстэй Эцэгийн хийсэн гэрээг би гүйцэлдүүлэх болно.
- 6 Мөн харийнхан адислагдсан болой, учир юун гэвэл миний тухай мөн Эцэгийн тухай тэдэнд гэрчлэх Ариун Сүнсээр ирдэг надад итгэх тэрхүү итгэлийнх нь учир билээ.
- 7 Болгоогтун, надад итгэх тэдний итгэлийн учир, мөн та нарын итгэлгүйн учир, Ай Израилын угсаа, хожмын өдөр эдгээр зүйлийн бүрэн байдал тэдэнд мэдүүлэгдэхийн тулд харийнханд үнэн ирэх болно хэмээн Эцэг хэлдэг.

### 3 Nephi 16

And verily, verily, I say unto you that I have other sheep, which are not of this land, neither of the land of Jerusalem, neither in any parts of that land round about whither I have been to minister.

For they of whom I speak are they who have not as yet heard my voice; neither have I at any time manifested myself unto them.

But I have received a commandment of the Father that I shall go unto them, and that they shall hear my voice, and shall be numbered among my sheep, that there may be one fold and one shepherd; therefore I go to show myself unto them.

And I command you that ye shall write these sayings after I am gone, that if it so be that my people at Jerusalem, they who have seen me and been with me in my ministry, do not ask the Father in my name, that they may receive a knowledge of you by the Holy Ghost, and also of the other tribes whom they know not of, that these sayings which ye shall write shall be kept and shall be manifested unto the Gentiles, that through the fulness of the Gentiles, the remnant of their seed, who shall be scattered forth upon the face of the earth because of their unbelief, may be brought in, or may be brought to a knowledge of me, their Redeemer.

And then will I gather them in from the four quarters of the earth; and then will I fulfil the covenant which the Father hath made unto all the people of the house of Israel.

And blessed are the Gentiles, because of their belief in me, in and of the Holy Ghost, which witnesses unto them of me and of the Father.

Behold, because of their belief in me, saith the Father, and because of the unbelief of you, O house of Israel, in the latter day shall the truth come unto the Gentiles, that the fulness of these things shall be made known unto them.

- 8 Гэвч Эцэг хэлдэг, харийнханы итгэлгүй тэдэнд халаг—учир нь тэд энэ нутгийн гадаргуу дээр ирсэн мөн Израилын угсааных болох миний хүмүүсийг тараасан; мөн Израилын угсааных болох миний хүмүүс тэдний дундаас зайлуулагдсан, мөн тэдний хөл дор тэднээр дэвслэгдсэн бөлгөө;
- 9 Мөн харийнханд хандах Эцэгийн нигүүлслийн, мөн түүнчлэн Израилын угсааных болох миний хүмүүсийн дээрх Эцэгийн шүүлтүүдийн учир, үнэнээр үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бүгдийн дараа, мөн Израилын угсааных болох өөрийн хүмүүсийг би цохигдож, мөн зовоогдон, мөн хөнөөгдөх, мөн тэдний дундаас зайлуулагдан, мөн тэднээр үзэн ядагдаж, мөн тэдний дунд муу хэлэгдэх болгосон мөн муугийн зүйр болгосон билээ—
- 10 Мөн Эцэг тийн зарлигласан, намайг та нарт ийн хэлэхийг: Харийнхан миний сайн мэдээний эсрэг нүгэл үйлдэж, мөн миний сайн мэдээний бүрэн байдлыг эсэргүүцэн, мөн бүх үндэстнүүдийн дээгүүр, мөн бүх газар дэлхийн бүх хүмүүсийн дээгүүр, зүрх сэтгэлийнхээ бардамналд хөөрч, мөн бүх төрлийн худал хэлж, мөн хуурч, мөн түүнчлэн бүх төрлийн хоёр нүүр гарган, мөн аллагууд, мөн санваараар мэргэших явдал, мөн садар самуун, мөн нууц жигшүүрт хэргүүдээр дүүрэх тэр өдөр; мөн хэрэв тэд эдгээр бүх зүйлийг хийж, мөн миний сайн мэдээний бүрэн байдлыг эсэргүүцвэл, болгоогтун, би сайн мэдээнийнхээ бүрэн байдлыг тэдний дундаас авах болно хэмээн Эцэг хэллээ.
- 11 Мөн тэгээд би өөрийн хүмүүстэй хийсэн гэрээгээ санах болно, Ай Израилын угсаа, мөн би тэдэнд сайн мэдээгээ авчрах болно.
- 12 Мөн, Ай Израилын угсаа, харийнхан чамайг давамгайлах хүчгүй гэдгийг би чамд үзүүлэх болно; харин би чамтай хийсэн гэрээгээ санах болно, Ай Израилын угсаа, мөн та нар миний сайн мэдээний бүрэн байдлын мэдлэгт ирэх болно.
- 13 Гэвч хэрэв харийнхан наманчилж мөн надад эргэж ирэх аваас, болгоогтун тэд миний хүмүүсийн, Ай Израилын угсааны дунд тоологдох болно хэмээн Эцэг хэлдэг.
- 14 Мөн Израилын угсаа болох өөрийн хүмүүсийг тэдний дундуур явж, мөн доош дэвслэхийг би зөвшөөрөхгүй хэмээн Эцэг хэлдэг.

But wo, saith the Father, unto the unbelieving of the Gentiles—for notwithstanding they have come forth upon the face of this land, and have scattered my people who are of the house of Israel; and my people who are of the house of Israel have been cast out from among them, and have been trodden under feet by them;

And because of the mercies of the Father unto the Gentiles, and also the judgments of the Father upon my people who are of the house of Israel, verily, verily, I say unto you, that after all this, and I have caused my people who are of the house of Israel to be smitten, and to be afflicted, and to be slain, and to be cast out from among them, and to become hated by them, and to become a hiss and a byword among them—

And thus commandeth the Father that I should say unto you: At that day when the Gentiles shall sin against my gospel, and shall reject the fulness of my gospel, and shall be lifted up in the pride of their hearts above all nations, and above all the people of the whole earth, and shall be filled with all manner of lyings, and of deceits, and of mischiefs, and all manner of hypocrisy, and murders, and priestcrafts, and whoredoms, and of secret abominations; and if they shall do all those things, and shall reject the fulness of my gospel, behold, saith the Father, I will bring the fulness of my gospel from among them.

And then will I remember my covenant which I have made unto my people, O house of Israel, and I will bring my gospel unto them.

And I will show unto thee, O house of Israel, that the Gentiles shall not have power over you; but I will remember my covenant unto you, O house of Israel, and ye shall come unto the knowledge of the fulness of my gospel.

But if the Gentiles will repent and return unto me, saith the Father, behold they shall be numbered among my people, O house of Israel.

And I will not suffer my people, who are of the house of Israel, to go through among them, and tread them down, saith the Father.



15 Гэвч хэрэв тэд надад хандахгүй, мөн дуу хоолойг минь анхааран сонсохгүй аваас, тэдний дундуур явахыг, мөн тэднийг доош дэвслэхийг би тэдэнд зөвшөөрөх болно, тийм ээ, би өөрийн хүмүүст, Ай Израилын угсаанд зөвшөөрөх болно, мөн тэд зайлуулагдаж, мөн Ай Израилын угсаа болох хүмүүсийн минь хөлд дэвслэгдэхээс өөр юунд ч хэрэггүй болох, амтаа алдсан давс лугаа адил байх болно.

16 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ—би энэ хүмүүст тэдний өв болгон энэ нутгийг өгөхийг Эцэг надад тийн зарлигласан билээ.

17 Мөн тэгээд бошиглогч Исаиагийн үгс гүйцэлдэх болно, үүнд:

18 Таны харуулууд дуу хоолойгоо өргөх болно; тэд дуу хоолойгоор хамтдаа дуулна; учир нь Их Эзэн Сионыг дахин авчрахыг тэд нүдээр үзэх болно.

19 Иерусалимын зэлүүд газрууд та нар баясан мөн хамтдаа дуулцгаа; учир нь Их Эзэн өөрийн хүмүүсийг тайтгаруулж, тэрээр Иерусалимыг гэтэлгэсэн болой.

20 Их Эзэн ариун мутраа бүх үндэстний нүдэнд харуулсан бөлгөө; мөн дэлхийн бүх хязгаарууд Бурханы авралыг үзэх болно.

But if they will not turn unto me, and hearken unto my voice, I will suffer them, yea, I will suffer my people, O house of Israel, that they shall go through among them, and shall tread them down, and they shall be as salt that hath lost its savor, which is thenceforth good for nothing but to be cast out, and to be trodden under foot of my people, O house of Israel.

Verily, verily, I say unto you, thus hath the Father commanded me—that I should give unto this people this land for their inheritance.

And then the words of the prophet Isaiah shall be fulfilled, which say:

Thy watchmen shall lift up the voice; with the voice together shall they sing, for they shall see eye to eye when the Lord shall bring again Zion.

Break forth into joy, sing together, ye waste places of Jerusalem; for the Lord hath comforted his people, he hath redeemed Jerusalem.

The Lord hath made bare his holy arm in the eyes of all the nations; and all the ends of the earth shall see the salvation of God.

### 3 Нифай 17

- 1 Болгоогтун, эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгсийг яриад тэрбээр цугласан олныг нүд гүйлгэн харав, мөн тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун, цаг минь ирлээ.
- 2 Та нар сул дорой, иймээс энэ үед та нарт ярихаар Эцэгээр надад зарлиг болгогдсон бүх үгсийг минь та нар ойлгож чадахгүйг би ухамсарлаж байна.
- 3 Тиймийн тул, та нар гэр гэртээ харьцгаа, мөн миний хэлсэн зүйлсийг эргэцүүлж, мөн, та нар ойлгож, мөн би та нарт дахин ирэх маргаашийн төлөө оюун санаагаа бэлтгэж болохын тулд миний нэрээр Эцэгээс асуу.
- 4 Гэвч эдүгээ би Эцэгт очиж, мөн түүнчлэн Израилын төөрөлдсөн овгуудад өөрийгөө үзүүлэхээр явлаа, учир нь Эцэгийн хувьд тэд төөрөлдөөгүй, учир нь тэрбээр тэднийг хааш аваачсаныгаа өөрөө мэддэг.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Есүс ийн яриад, тэрбээр дахин цугларсан олны зүг хараа бэлчээж, мөн тэд нулимс унагаж буйг, мөн тэд өөрийг нь тэдэнтэй хамт дахин хэсэгхэн зуур ч гэсэн үлдэхийг гуйх мэт түүний зүг тэд ширтэн харж байхыг болгоов.
- 6 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун, та нарт хандсан өрөвдөх сэтгэлээр зүрх сэтгэл минь дүүрэв.
- 7 Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг нааш авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, эсвээс уяман өвчтэй, эсвээс татанги, эсвээс дүлий, эсвээс ямар нэгэн байдалд зовж зүдэрсэн нэгэн байна уу? Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно, учир нь та нарыг өрөвдөх сэтгэл надад буй; зүрх сэтгэл минь нигүүлслээр дүүрэв.
- 8 Учир нь Иерусалим дахь ах дүүст тань миний юу хийснийг өөрсдөд тань үзүүлээсэй хэмээх та нарын хүслийг би ухамсарлаж байна, учир нь та нарыг эдгээхэд итгэл тань хангалттайг би харж байна.
- 9 Мөнхүү улиран тохиох дор түүнийг тийн ярихад, бүх цугласан олон, нэгэн зэрэг, өвчтэй мөн зовж зүдэрсэн, мөн доголон, мөн хараагүй, мөн хэлгүй, мөн ямар нэгэн байдлаар зовж зүдэрсэн тэд бүгдтэйгээ урагшлав; мөн тэрбээр тэднийг түүнд авчрагдахад нэг бүрчлэн эдгээв.

### 3 Nephi 17

Behold, now it came to pass that when Jesus had spoken these words he looked round about again on the multitude, and he said unto them: Behold, my time is at hand.

I perceive that ye are weak, that ye cannot understand all my words which I am commanded of the Father to speak unto you at this time.

Therefore, go ye unto your homes, and ponder upon the things which I have said, and ask of the Father, in my name, that ye may understand, and prepare your minds for the morrow, and I come unto you again.

But now I go unto the Father, and also to show myself unto the lost tribes of Israel, for they are not lost unto the Father, for he knoweth whither he hath taken them.

And it came to pass that when Jesus had thus spoken, he cast his eyes round about again on the multitude, and beheld they were in tears, and did look steadfastly upon him as if they would ask him to tarry a little longer with them.

And he said unto them: Behold, my bowels are filled with compassion towards you.

Have ye any that are sick among you? Bring them hither. Have ye any that are lame, or blind, or halt, or maimed, or leprous, or that are withered, or that are deaf, or that are afflicted in any manner? Bring them hither and I will heal them, for I have compassion upon you; my bowels are filled with mercy.

For I perceive that ye desire that I should show unto you what I have done unto your brethren at Jerusalem, for I see that your faith is sufficient that I should heal you.

And it came to pass that when he had thus spoken, all the multitude, with one accord, did go forth with their sick and their afflicted, and their lame, and with their blind, and with their dumb, and with all them that were afflicted in any manner; and he did heal them every one as they were brought forth unto him.

10 Мөн тэд бүгд, эдгээгдсэн тэд мөн эрүүл байсан тэд аль аль нь, түүний хөлд доош бөхийн мөн түүнийг бишрэв; мөн цугласан нь олон байсан хэдий ч, ирж чадсан болгон нь түүний хөлийг үнсэж, үүний хэрээр түүний хөлийг тэд нулимсаараа булхав.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэдний бяцхан хүүхдүүд авчрагдахыг зарлиг болгов.

12 Иймээс тэд бяцхан хүүхдүүдээ авчирч мөн тэднийг түүний эргэн тойронд газарт доош тавив, мөн Есүс голд нь зогсов; мөн цугласан олон тэднийг түүнд бүгдийг нь авчрах хүртэл зай тавьж өгөв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд авчрагдаж, мөн Есүс голд нь зогсоод, тэрбээр цугласан олонд тэд доош газарт сөхрөхийг зарлиг болов.

14 Мөнхүү улиран тохиох дор тэднийг газарт сөхөрцгөөхөд, Есүс дотроо санаа алдан, мөн хэлэв: Эцэг минь, Израилын угсааны хүмүүсийн ёс бусын учир би шаналнам.

15 Мөн тэрээр эдгээр үгийг хэлээд, тэр өөрөө түүнчлэн газар дээр сөхрөв; мөн болгоогтун тэр Эцэгт хандан залбирав, мөн түүний залбирсан зүйлүүд бичигдэх аргагүй байлаа, мөн түүнийг сонссон олон түмэн гэрчилсэн билээ.

16 Мөнхүү ийм маягаар тэд гэрчилдэг: Эцэгт хандан Есүсийн ярьсныг бид харж мөн сонссон шиг тийм агуу хийгээд гайхамшигт зүйлүүд урьд нь нүдэнд хэзээ ч үзэгдээгүй, бас чихэнд хэзээ ч сонсогдоогүй бөлгөө;

17 Мөн Есүсийн ярьсныг бидний харж бас сонссон шиг тийм агуу хийгээд гайхамшигт зүйлсийг хэлээр хэлэх аргагүй, бас ямар ч хүмүүнээр бичигдэх аргагүй, бас хүмүүн зүрх сэтгэлдээ төсөөлөхийн аргагүй; мөн бидний төлөө Эцэгт хандан түүний залбирсныг бид сонссон тэр цагт бодгалийг маань дүүргэсэн тэрхүү баяслыг хэн ч төсөөлж чадахгүй буйза.

18 Мөнхүү улиран тохиох дор Эцэгт хандсан залбирлаа Есүс дуусгаад, тэр босов; харин олон түмний баясал ийм агуу их байснаас тэд халгилан тэнхээ алдрав.

19 Мөнхүү улиран тохиох дор Есүс тэдэнд ярьж, мөн босохыг тэдэнд тушаав.

And they did all, both they who had been healed and they who were whole, bow down at his feet, and did worship him; and as many as could come for the multitude did kiss his feet, insomuch that they did bathe his feet with their tears.

And it came to pass that he commanded that their little children should be brought.

So they brought their little children and set them down upon the ground round about him, and Jesus stood in the midst; and the multitude gave way till they had all been brought unto him.

And it came to pass that when they had all been brought, and Jesus stood in the midst, he commanded the multitude that they should kneel down upon the ground.

And it came to pass that when they had knelt upon the ground, Jesus groaned within himself, and said: Father, I am troubled because of the wickedness of the people of the house of Israel.

And when he had said these words, he himself also knelt upon the earth; and behold he prayed unto the Father, and the things which he prayed cannot be written, and the multitude did bear record who heard him.

And after this manner do they bear record: The eye hath never seen, neither hath the ear heard, before, so great and marvelous things as we saw and heard Jesus speak unto the Father;

And no tongue can speak, neither can there be written by any man, neither can the hearts of men conceive so great and marvelous things as we both saw and heard Jesus speak; and no one can conceive of the joy which filled our souls at the time we heard him pray for us unto the Father.

And it came to pass that when Jesus had made an end of praying unto the Father, he arose; but so great was the joy of the multitude that they were overcome.

And it came to pass that Jesus spake unto them, and bade them arise.

20 Мөн тэд газраас босч, мөн тэрээр тэдэнд хэлсэн нь: Итгэлийнхээ учир адислагдсан болой та нар. Мөн эдүгээ болгоогтун, миний баясал дүүрэн байна.

21 Мөн тэрээр эдгээр үгсийг хэлээд, уйлж, мөн олон түмэн үүнийг гэрчлэв, мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.

22 Мөн тэр үүнийг хийгээд тэрээр дахин уйлав;

23 Мөн тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.

24 Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг тэд үзэв, мөн тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; мөн тэд доош ирж мөн багачуудыг эргэн тойрон хүрээлж, мөн тэд галаар эргэн тойрондоо хүрээлэгдсэн байв; мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулав.

25 Мөн цугласан олон үзэж мөн сонсож мөн гэрчлэв; мөн тэд өөрсдийнх нь цэдэг үнэнийг мэддэг, учир нь тэд бүгд өөрийн биеэр үзэж мөн сонссон болой; мөн тэд тоогоороо хоёр мянга таван зуу орчим бодгаль байв; мөн тэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдээс бүрдэж байв.

And they arose from the earth, and he said unto them: Blessed are ye because of your faith. And now behold, my joy is full.

And when he had said these words, he wept, and the multitude bare record of it, and he took their little children, one by one, and blessed them, and prayed unto the Father for them.

And when he had done this he wept again;

And he spake unto the multitude, and said unto them: Behold your little ones.

And as they looked to behold they cast their eyes towards heaven, and they saw the heavens open, and they saw angels descending out of heaven as it were in the midst of fire; and they came down and encircled those little ones about, and they were encircled about with fire; and the angels did minister unto them.

And the multitude did see and hear and bear record; and they know that their record is true for they all of them did see and hear, every man for himself; and they were in number about two thousand and five hundred souls; and they did consist of men, women, and children.

### 3 Нифай 18

- 1 Мөнхүү улиран тохиох дор өөртөө хэсэг талх мөн дарс авчрахыг Есүс шавь нартаа зарлиг болгов.
- 2 Мөн тэднийг талх мөн дарсанд явсан хойгуур, тэд газар дээр доош сууцгаахыг тэрбээр цугласан олонд зарлиглав.
- 3 Мөн шавь нар нь талх мөн дарстай ирэхэд, тэрбээр талхнаас авч мөн хуваагаад мөн үүнийгээ адислав; мөн тэрбээр шавь нартаа өгч мөн тэдэнд идэхийг зарлиг болгов.
- 4 Мөн тэд идэж мөн ханахад, тэрбээр тэдэнд цугласан олонд өгөхийг зарлиглав.
- 5 Мөн цугласан олон идээд мөн ханахад, тэрбээр шавь нартаа хэлэв: Болгоогтун та нарын дундаас томилогдох нэг нь байх болно, мөн би түүнд хүчийг өгснөөр тэрбээр талхыг хувааж мөн үүнийгээ адислан мөн миний сүмийн хүмүүст, итгэж мөн миний нэрээр баптисм хүртэх тэд бүгдэд үүнийг өгөх болно.
- 6 Мөн үүнийг та нар хийхээр, бүр яг миний хийсэн шигээр, би талхыг хувааж мөн үүнийг адисалж мөн үүнийг та нарт өгсний адилаар үргэлж чармайх болно.
- 7 Мөн та нар үүнийг та нарт миний үзүүлснээр миний бие махбодийг төлөөлөн дурсаж үйлдэх болно. Мөн энэ нь Эцэгт та нар намайг үргэлж дурсан санаж байгаагийн гэрчлэл байх болно. Мөн хэрэв та нар намайг үргэлж санах аваас, миний Сүнс та нартай хамт байх болно.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр эдгээр үгийг хэлээд, тэд аяган дахь дарснаас авч мөн үүнээс уухыг, мөн түүнчлэн тэд ууж болохын тулд цугласан олонд өгөхийг тэр шавь нартаа зарлиг болгов.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд үүнчлэн үйлдэж, мөн үүнээс ууж мөн ханав; мөн тэд цугласан олонд өгч, мөн тэд ууж, мөн тэд ханацгаав.
- 10 Мөн шавь нар нь үүнийг үйлдэхэд, Есүс тэдэнд хэлэв: Үйлдсэн энэ зүйлийнхээ төлөө адислагдсан болой та нар, учир нь энэ нь миний зарлигуудыг гүйцэлдүүлж, мөн та нар, өөрсдөдөө миний зарлигласныг үйлдэхэд бэлэн буйг энэ нь Эцэгт гэрчилдэг билээ.

### 3 Nephi 18

And it came to pass that Jesus commanded his disciples that they should bring forth some bread and wine unto him.

And while they were gone for bread and wine, he commanded the multitude that they should sit themselves down upon the earth.

And when the disciples had come with bread and wine, he took of the bread and brake and blessed it; and he gave unto the disciples and commanded that they should eat.

And when they had eaten and were filled, he commanded that they should give unto the multitude.

And when the multitude had eaten and were filled, he said unto the disciples: Behold there shall one be ordained among you, and to him will I give power that he shall break bread and bless it and give it unto the people of my church, unto all those who shall believe and be baptized in my name.

And this shall ye always observe to do, even as I have done, even as I have broken bread and blessed it and given it unto you.

And this shall ye do in remembrance of my body, which I have shown unto you. And it shall be a testimony unto the Father that ye do always remember me. And if ye do always remember me ye shall have my Spirit to be with you.

And it came to pass that when he said these words, he commanded his disciples that they should take of the wine of the cup and drink of it, and that they should also give unto the multitude that they might drink of it.

And it came to pass that they did so, and did drink of it and were filled; and they gave unto the multitude, and they did drink, and they were filled.

And when the disciples had done this, Jesus said unto them: Blessed are ye for this thing which ye have done, for this is fulfilling my commandments, and this doth witness unto the Father that ye are willing to do that which I have commanded you.

- 11 Мөн наманчилж мөн миний нэрээр баптисм хүртсэн тэдэнд та нар үүнийг үргэлж үйлдэх болно; мөн та нарын төлөө асгаруулсан миний цусыг төлөөлөн дурсаж, та нар үргэлж намайг санаж байгаагаа Эцэгт гэрчилж болохын тулд та нар үүнийг үйлдэх болно. Мөн хэрэв та нар намайг үргэлж санах юм бол миний Сүнс та нартай хамт байх болно.
- 12 Мөн эдгээр зүйлийг та нар үйлдэх болно хэмээх зарлигийг би та нарт өгч байна. Мөн хэрэв та нар эдгээр зүйлийг үргэлж үйлдэх аваас адислагдах болой та нар, учир нь та нар миний хадан дээр барьж босгогдсон билээ.
- 13 Гэвч та нарын дундаас үүнээс илүүг эсвээс дутууг үйлдэх хэн боловч тэд миний хадан дээр барьж босгоогүй, харин элсэрхэг суурин дээр барьж босгосон ажгуу; мөн бороо цутгаж, бас үер бууж, тэгээд салхи үлээж, мөн тэднийг цохиход, тэд унах болно, мөн тамынүүд тэднийг хүлээн авахаар бэлэн нээлттэй байна.
- 14 Тиймийн тул намайг та нарт өгөхийг Эцэг надад зарлигласан тэрхүү зарлигуудыг минь хэрэв та нар дагах аваас адислагдсан болой та нар.
- 15 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, та нар чөтгөрөөр уруу татагдаж, мөн та нар түүгээр боолчлогдон удирдагдах болуузай хэмээн та нар үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой.
- 16 Мөн наманчилдаг мөн миний нэрээр баптисм хүртдэг миний хүмүүсийн дунд, би та нарын дунд залбирсан шиг, та нар түүнчлэн миний сүмд залбирах болно. Болгоогтун би бол гэрэл; би та нарт үлгэржишээ үзүүлсэн билээ.
- 17 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг шавь нартаа яриад, тэрбээр дахин цугласан олонд хандаж мөн тэдэнд хэлэв:
- 18 Болгоогтун, үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, та нар уруу таталтанд орохгүйн тулд үргэлж сэрэмжилж мөн залбирах ёстой; учир нь тэр та нарыг буудай мэт шигшиж болохын тулд Сатан та нарыг эзэмдэхийг хүсч байна.
- 19 Тиймийн тул та нар миний нэрээр Эцэгт үргэлж залбирах ёстой;

And this shall ye always do to those who repent and are baptized in my name; and ye shall do it in remembrance of my blood, which I have shed for you, that ye may witness unto the Father that ye do always remember me. And if ye do always remember me ye shall have my Spirit to be with you.

And I give unto you a commandment that ye shall do these things. And if ye shall always do these things blessed are ye, for ye are built upon my rock.

But whoso among you shall do more or less than these are not built upon my rock, but are built upon a sandy foundation; and when the rain descends, and the floods come, and the winds blow, and beat upon them, they shall fall, and the gates of hell are ready open to receive them.

Therefore blessed are ye if ye shall keep my commandments, which the Father hath commanded me that I should give unto you.

Verily, verily, I say unto you, ye must watch and pray always, lest ye be tempted by the devil, and ye be led away captive by him.

And as I have prayed among you even so shall ye pray in my church, among my people who do repent and are baptized in my name. Behold I am the light; I have set an example for you.

And it came to pass that when Jesus had spoken these words unto his disciples, he turned again unto the multitude and said unto them:

Behold, verily, verily, I say unto you, ye must watch and pray always lest ye enter into temptation; for Satan desireth to have you, that he may sift you as wheat.

Therefore ye must always pray unto the Father in my name;

20 Мөн та нар хүлээж авах болно гэж итгээд, миний нэрээр Эцэгээс гуйх, зөв болох юу боловч, болгоогтун энэ нь та нарт өгөгдөх болно.

21 Эхнэрүүд хийгээд хүүхдүүд чинь адислагдаж болохын тулд, гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж залбир.

22 Мөн болгоогтун, та нар ойр ойрхон цуглан уулзацгаах болно; мөн та нар нэг ч хүнийг та нар цуглах үедээ ирэхийг хориглохгүй, харин тэд та нарт ирэхийг тэдэнд зөвшөөрч мөн тэднийг хориглохгүй байх болно;

23 Харин та нар тэдний төлөө залбирах болно, мөн тэднийг зайлуулахгүй байх болно; мөн хэрэв тэд ойр ойрхон та нарт ирэх аваас та нар тэдний төлөө Эцэгт миний нэрээр залбирах болно.

24 Тиймийн тул, дэлхийд туяарч болохын тулд гэрлээ өргөгтүн. Болгоогтун би бол та нарын өргөх тэрхүү гэрэл билээ—та нарын харсан тэдгээр нь миний үйлдсэн зүйлүүд болой. Болгоогтун Эцэгт хандан залбирахыг минь та нар харсан, мөн та нар бүгдээрээ харсан билээ.

25 Мөн би та нарын хэнийг нь ч зайлан явахыг та нарт зарлиг болгосонгүй, харин ч эсрэгээр та нар тэмтэрч мөн харж болохын тулд надад ирэхийг та нарт зарлиг болгосоныг та нар харж байна; та нар түүнчлэн дэлхийхэнд үйлдэх болно; мөн энэ зарлигийг эвдсэн хэн боловч тэрбээр өөрийгөө уруу таталтанд удирдагдахыг хүлцдэг.

26 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад, тэрбээр өөрийн сонгосон шавь нартаа дахин харцаа хандуулж, мөн тэдэнд хэлэв:

27 Болгоогтун үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, би өөр нэг зарлигийг та нарт өгч байна, мөн тэгээд би надад түүний өгсөн өөр зарлигуудыг гүйцэлдүүлж болохын тулд би Эцэгтээ очих ёстой.

28 Мөн эдүгээ болгоогтун, энэ бол та нарт өгөх миний зарлиг, та нар үүнийг адислан түгээхдээ хэн нэгэн миний махбодь болон цусыг зохисгүйгээр хүртэхийг та нар мэдсээр байж хүлцэж болохгүй;

And whatsoever ye shall ask the Father in my name, which is right, believing that ye shall receive, behold it shall be given unto you.

Pray in your families unto the Father, always in my name, that your wives and your children may be blessed.

And behold, ye shall meet together oft; and ye shall not forbid any man from coming unto you when ye shall meet together, but suffer them that they may come unto you and forbid them not;

But ye shall pray for them, and shall not cast them out; and if it so be that they come unto you oft ye shall pray for them unto the Father, in my name.

Therefore, hold up your light that it may shine unto the world. Behold I am the light which ye shall hold up—that which ye have seen me do. Behold ye see that I have prayed unto the Father, and ye all have witnessed.

And ye see that I have commanded that none of you should go away, but rather have commanded that ye should come unto me, that ye might feel and see; even so shall ye do unto the world; and whosoever breaketh this commandment suffereth himself to be led into temptation.

And now it came to pass that when Jesus had spoken these words, he turned his eyes again upon the disciples whom he had chosen, and said unto them:

Behold verily, verily, I say unto you, I give unto you another commandment, and then I must go unto my Father that I may fulfil other commandments which he hath given me.

And now behold, this is the commandment which I give unto you, that ye shall not suffer any one knowingly to partake of my flesh and blood unworthily, when ye shall minister it;

29 Учир нь миний бие махбодь болон цусыг зохисгүйгээр идэж мөн уух хэн боловч бодгальдаа ялыг идэж мөн уудаг; тиймийн тул хэрэв хэн нэгэн миний махбодь мөн цусыг идэх мөн уух нь зохистой бусыг та нар мэдэх аваас та нар түүнийг хориглох болно.

30 Гэсэн хэдий ч, та нар түүнийг өөрсдийн дундаас зайлуулахгүй, харин та нар түүнд тохинуулж мөн миний нэрээр, Эцэгт хандан түүний төлөө залбирах болно; мөн хэрэв тэрбээр наманчилж мөн миний нэрээр баптисм хүртэх аваас, тэгвэл та нар түүнийг хүлээн зөвшөөрч, мөн миний махбодь болон цуснаас түүнд адислан түгээх болно.

31 Харин хэрэв тэр наманчлахгүй аваас тэрбээр миний хүмүүсийг устгаж болохгүйн тулд, тэрбээр миний хүмүүсийн дунд тоологдохгүй, учир нь болгоогтун би хонинуудаа мэднэ, мөн тэд тоологдсон билээ.

32 Гэсэн хэдий ч, та нар түүнийг синагогуудаасаа, эсвэл шүтлэгийн байруудаасаа хөөхгүй, учир нь тийм нэгэнд та нар үргэлжлүүлэн тохинуулах болно; учир нь, тэд эргэж ирээд мөн наманчилж, мөн зүрх сэтгэлийнхээ бүх тэмүүлээр надад ирж мөн би тэднийг эдгээх ажгуу; мөн та нар тэдэнд авралыг авчрах хэрэгсэл байх эсэхийг та нар мэдэхгүй.

33 Тиймийн тул, та нар буруушаалтанд өртөхгүйн тулд та нарт миний зарлигласан эдгээр үгсийг дагагтун; учир нь Эцэг буруушаасан түүнд халаг.

34 Мөн та нарын дунд байсан арцалдааны учир би эдгээр зарлигуудыг та нарт өгч байна. Мөн хэрэв та нарын дунд арцалдаанууд үгүй аваас адислагдсан болой та нар.

35 Мөн эдүгээ би Эцэгт очно, учир нь би та нарын тусын тулд Эцэгт очих нь зайлшгүй юм.

36 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг төгсгөл болгоод, тэрбээр өөрөө сонгосон шавь нартаа гараа хүргэж, нэг нэгээр нь, бүр тэднийг бүгдэд нь хүрэх хүртлээ, мөн тэрбээр тэдэнд хүрэхийн хамтаар тэдэнд ярив.

37 Мөн цугласан олон түүний ярьсан үгсийг сонссонгүй, тиймийн тул тэд гэрчилсэнгүй; гэвч тэрбээр Ариун Сүнснийг өгөх хүчийг тэдэнд олгосон хэмээн шавь нар нь гэрчилсэн болой. Мөн энэ цэдэг үнэн гэдгийг би та нарт цаашид үзүүлэх болно.

For whoso eateth and drinketh my flesh and blood unworthily eateth and drinketh damnation to his soul; therefore if ye know that a man is unworthy to eat and drink of my flesh and blood ye shall forbid him.

Nevertheless, ye shall not cast him out from among you, but ye shall minister unto him and shall pray for him unto the Father, in my name; and if it so be that he repenteth and is baptized in my name, then shall ye receive him, and shall minister unto him of my flesh and blood.

But if he repent not he shall not be numbered among my people, that he may not destroy my people, for behold I know my sheep, and they are numbered.

Nevertheless, ye shall not cast him out of your synagogues, or your places of worship, for unto such shall ye continue to minister; for ye know not but what they will return and repent, and come unto me with full purpose of heart, and I shall heal them; and ye shall be the means of bringing salvation unto them.

Therefore, keep these sayings which I have commanded you that ye come not under condemnation; for wo unto him whom the Father condemneth.

And I give you these commandments because of the disputations which have been among you. And blessed are ye if ye have no disputations among you.

And now I go unto the Father, because it is expedient that I should go unto the Father for your sakes.

And it came to pass that when Jesus had made an end of these sayings, he touched with his hand the disciples whom he had chosen, one by one, even until he had touched them all, and spake unto them as he touched them.

And the multitude heard not the words which he spake, therefore they did not bear record; but the disciples bare record that he gave them power to give the Holy Ghost. And I will show unto you hereafter that this record is true.



38 Мөнхүү улиран тохиох дор Есүс тэдэнд бүгдэд нь хүрэхэд, үүл бууж мөн тэд Есүсийг харж чадахааргүй болгож цугласан олныг сүүдэрлэв.

39 Мөн тэднийг сүүдэрлэгдсэн байхад тэрбээр тэднээс одож, мөн тэнгэрт дээш одов. Мөн шавь нар нь харж мөн тэрбээр тэнгэр өөд дахин дээшлэн одсныг гэрчлэв.

And it came to pass that when Jesus had touched them all, there came a cloud and overshadowed the multitude that they could not see Jesus.

And while they were overshadowed he departed from them, and ascended into heaven. And the disciples saw and did bear record that he ascended again into heaven.

### 3 Нифай 19

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүсийг тэнгэрт дээшлэн одоход, цугласан олон тархав, мөн хүн бүр эхнэрээ мөн хүүхдүүдээ авч мөн гэртээ эргэж харив.
- 2 Мөн цугласан олон Есүсийг харсан, мөн тэрбээр тэдэнд тохинуулсан, мөн тэрбээр түүнчлэн маргааш нь цугласан олонд өөрийгөө үзүүлэх болно гэсэн нь тэр даруй харанхуй болохоос өмнө хүмүүсийн дунд тархан сонсогдов.
- 3 Тийм ээ, мөн бүр бүхэл шөнөжингөө Есүсийн талаар тархан сонсогдов; мөн үүний хэрээр тэд хүмүүст дамжуулснаас тэнд олон нь байв, тийм ээ, үлэмж их тоотой, тэд маргааш нь Есүс өөрийгөө цугласан олонд үзүүлэх тэр газар байж болохын тулд бүхэл шөнөжингөө үлэмж шаргуу хөдөлмөрлөв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь, олон түмнийг нэгдэн цугларахад, болгоогтун, Нифай мөн нас барагсдаас түүний босгосон, нэр нь Тимофи гэдэг дүү нь, мөн түүнчлэн нэр нь Жонас асан түүний хүү, мөн түүнчлэн Мафони, мөн түүнчлэн Мафонайха, түүний дүү, мөн Күмен, мөн Күменонхай, мөн Иеремиа, мөн Шемнон, мөн Жонас, мөн Зедикая, мөн Исаиа—эдүгээ тэд бол Есүсийн сонгосон шавь нарынх нь нэрс байв—мөнхүү улиран тохиох дор тэд явж мөн цугласан олны дунд зогсов.
- 5 Мөн болгоогтун, цугласан олон тийм агуу байснаас тэднийг арван хоёр хэсэгт тусгаарлагдсан байхаар тэд болгов.
- 6 Мөнхүү арван хоёр цугласан олонд заав; мөн болгоогтун, тэд цугласан олныг газрын гадаргуу дээр доош сөхөрч, мөн Есүсийн нэрээр Эцэгт хандан залбирах болгов.
- 7 Мөнхүү шавь нар нь түүнчлэн Есүсийн нэрээр Эцэгт хандан залбирав. Мөнхүү улиран тохиох дор тэд босож мөн хүмүүст тохинуулав.
- 8 Мөн тэд Есүсийн ярьсны нэгэн адил үгсээр тохиуулсны дараа—Есүсийн ярьсан үгсээс юу ч зөрүүлэхгүйгээр—болгоогтун, тэд дахин сөхөрч мөн Есүсийн нэрээр Эцэгт хандан залбирав.
- 9 Мөн тэд хамгийн их хүссэн түүнийхээ төлөө залбирав; мөн Ариун Сүнс өөрсдөд нь өгөгдөхийг тэд хүсэв.

### 3 Nephi 19

And now it came to pass that when Jesus had ascended into heaven, the multitude did disperse, and every man did take his wife and his children and did return to his own home.

And it was noised abroad among the people immediately, before it was yet dark, that the multitude had seen Jesus, and that he had ministered unto them, and that he would also show himself on the morrow unto the multitude.

Yea, and even all the night it was noised abroad concerning Jesus; and insomuch did they send forth unto the people that there were many, yea, an exceedingly great number, did labor exceedingly all that night, that they might be on the morrow in the place where Jesus should show himself unto the multitude.

And it came to pass that on the morrow, when the multitude was gathered together, behold, Nephi and his brother whom he had raised from the dead, whose name was Timothy, and also his son, whose name was Jonas, and also Mathoni, and Mathonihah, his brother, and Kumen, and Kumenonhi, and Jeremiah, and Shemnon, and Jonas, and Zedekiah, and Isaiah—now these were the names of the disciples whom Jesus had chosen—and it came to pass that they went forth and stood in the midst of the multitude.

And behold, the multitude was so great that they did cause that they should be separated into twelve bodies.

And the twelve did teach the multitude; and behold, they did cause that the multitude should kneel down upon the face of the earth, and should pray unto the Father in the name of Jesus.

And the disciples did pray unto the Father also in the name of Jesus. And it came to pass that they arose and ministered unto the people.

And when they had ministered those same words which Jesus had spoken—nothing varying from the words which Jesus had spoken—behold, they knelt again and prayed to the Father in the name of Jesus.

And they did pray for that which they most desired; and they desired that the Holy Ghost should be given unto them.

10 Мөн тэд тийн залбираад тэд уруудан усны захад очиход, мөн цугласан олон тэднийг дагав.

11 Мөнхүү улиран тохиох дор Нифай ус уруу орж мөн баптисм хүртэв.

12 Мөн тэрбээр уснаас гарч ирээд мөн баптисм хүртээж эхлэв. Мөн тэрбээр Есүсийн сонгосон тэд бүгдэд баптисм хүртээв.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд баптисм хүртэхэд мөн уснаас гарч ирэхэд, Ариун Сүнс тэдний дээр бууж, мөн тэд Ариун Сүнсээр мөн галаар дүүргэгдэв.

14 Мөн болгоогтун, тэд галаар лугаа адил хүрээлэгдэв, мөн энэ нь тэнгэрээс бууж ирсэн аж, мөн цугласан олон үүнийг үзэж, мөн гэрчлэв; мөн тэнгэр элчүүд тэнгэрээс бууж ирээд мөн тэдэнд тохинуулав.

15 Мөнхүү улиран тохиох дор тэнгэр элчүүд шавь нарт нь тохинуулж байх зуур, болгоогтун, Есүс ирж мөн дунд нь зогсоод мөн тэдэнд тохинуулав.

16 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр цугласан олонд ярьж, мөн тэдэнд дахин газарт сөхрөхийг, мөн түүнчлэн шавь нараа газарт сөхрөхийг зарлиг болгов.

17 Мөнхүү улиран тохиох дор тэднийг бүгд газарт сөхрөхөд, тэрбээр шавь нартаа тэд залбирахыг зарлиг болгов.

18 Мөн болгоогтун, тэд залбирч эхлэв; мөн түүнийг өөрсдийн Их Эзэн мөн өөрсдийн Бурхан хэмээн дуудаж тэд Есүст залбирав.

19 Мөнхүү улиран тохиох дор Есүс тэдний дундаас одож, мөн тэднээс бага зэрэг холдоод мөн доош бөхийн, мөн тэрээр хэлэв:

20 Эцэг минь, миний сонгосон эдэнд Ариун Сүнсийг өгсөнд тань танд талархъя; мөн надад итгэх тэдний итгэлийн учир би тэднийг дэлхийнхнээс сонгосон билээ.

21 Эцэг минь, тэдний үгсэд итгэх тэр бүгдэд Ариун Сүнсийг өгөөч хэмээн би танд залбирна.

22 Эцэг минь, тэд надад итгэдэг учир та тэдэнд Ариун Сүнсийг өгсөн билээ; мөн тэд надад залбирч буйг та сонсож байгаа учир тэд надад итгэдгийг та харж байна; мөн би тэдэнтэй хамт байгаа учраас тэд надад хандан залбирч байна.

And when they had thus prayed they went down unto the water's edge, and the multitude followed them.

And it came to pass that Nephi went down into the water and was baptized.

And he came up out of the water and began to baptize. And he baptized all those whom Jesus had chosen.

And it came to pass when they were all baptized and had come up out of the water, the Holy Ghost did fall upon them, and they were filled with the Holy Ghost and with fire.

And behold, they were encircled about as if it were by fire; and it came down from heaven, and the multitude did witness it, and did bear record; and angels did come down out of heaven and did minister unto them.

And it came to pass that while the angels were ministering unto the disciples, behold, Jesus came and stood in the midst and ministered unto them.

And it came to pass that he spake unto the multitude, and commanded them that they should kneel down again upon the earth, and also that his disciples should kneel down upon the earth.

And it came to pass that when they had all knelt down upon the earth, he commanded his disciples that they should pray.

And behold, they began to pray; and they did pray unto Jesus, calling him their Lord and their God.

And it came to pass that Jesus departed out of the midst of them, and went a little way off from them and bowed himself to the earth, and he said:

Father, I thank thee that thou hast given the Holy Ghost unto these whom I have chosen; and it is because of their belief in me that I have chosen them out of the world.

Father, I pray thee that thou wilt give the Holy Ghost unto all them that shall believe in their words.

Father, thou hast given them the Holy Ghost because they believe in me; and thou seest that they believe in me because thou hearest them, and they pray unto me; and they pray unto me because I am with them.

23 Мөн эдүгээ Эцэг минь, тэдний төлөө, мөн түүнчлэн тэдний үгсэд итгэх тэд бүгдийн төлөө, тэд надад итгэж болохын тулд, Эцэг минь, та надад байдгийн адил, би тэдэнд байж болохын тулд, бид нэг байж болохын тулд би танд хандан залбирч байна.

24 Мөнхүү улиран тохиох дор Есүс ийн Эцэгт залбираад, тэрбээр шавь нартаа ирж, мөн болгоогтун, тэд зогсолтгүйгээр бас л үргэлжлүүлэн түүнд залбирсаар байв; мөн тэд олон үг нуршсангүй, учир нь тэд юу гэж залбирах нь тэдэнд өгөгдсөн байв, мөн тэд хүслээр дүүргэгдэв.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд түүнд хандан залбирах үед Есүс тэднийг адислав; мөн түүний дүр тэдний дээр инээмсэглэж, мөн түүний дүр төрхийн гэрэл тэдний дээр гийгүүлж, мөн болгоогтун тэд Есүсийн төрх болон түүний өмсгөл лугаа адил цагаан байлаа; мөн болгоогтун тэдний цагаан нь цагаан бүхнээс үлэмж байв, тийм ээ, бүр түүний цагаан шиг тийм цагаан юм юу ч дэлхийд байх аргагүй билээ.

26 Мөн Есүс тэдэнд хэлэв: Үргэлжлүүлэн залбирагтун; мөнхүү тэгээд тэд залбирахаа зогссонгүй.

27 Мөн тэрбээр тэднээс дахин эргэж, мөн бага зэрэг холдоод мөн доош бөхийж; мөн тэрбээр дахин Эцэгт хандан залбирч, хэлсэн нь:

28 Эцэг минь, итгэлийнх нь учир миний сонгосон тэднийг ариусгасанд тань талархъя, мөн би тэдний төлөө, тэд надаар ариусгагдсантай адил, тэдний үгсэд итгэх итгэлээрээ дамжуулан тэд надаар ариусгагдаж болохын тулд мөн түүнчлэн тэдний үгсэд итгэх тэдний төлөө залбирч.

29 Эцэг минь, дэлхийн төлөө бус, харин дэлхийгээс тэдний итгэлийн учир надад таны өгсөн тэдний төлөө, тэд надаар ариусгагдаж болохын тулд, Эцэг минь, та надад байдгийн адил, би тэдэнд байж болохын тулд, бид нэг байж болохын тулд, би тэднээр алдаршуулагдаж болохын тулд би залбирч байна.

30 Мөн Есүс эдгээр үгсийг яриад тэрбээр шавь нартаа дахин ирэв; мөн болгоогтун тэд зогсолтгүйгээр түүнд хандан тууштайгаар залбирсаар байв; мөн тэрбээр тэдний дээр дахин инээмсэглэв; мөн болгоогтун тэд бүр Есүс шиг цагаан байв.

31 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр дахин бага зэрэг холдоод мөн Эцэгт хандан залбирав;

And now Father, I pray unto thee for them, and also for all those who shall believe on their words, that they may believe in me, that I may be in them as thou, Father, art in me, that we may be one.

And it came to pass that when Jesus had thus prayed unto the Father, he came unto his disciples, and behold, they did still continue, without ceasing, to pray unto him; and they did not multiply many words, for it was given unto them what they should pray, and they were filled with desire.

And it came to pass that Jesus blessed them as they did pray unto him; and his countenance did smile upon them, and the light of his countenance did shine upon them, and behold they were as white as the countenance and also the garments of Jesus; and behold the whiteness thereof did exceed all the whiteness, yea, even there could be nothing upon earth so white as the whiteness thereof.

And Jesus said unto them: Pray on; nevertheless they did not cease to pray.

And he turned from them again, and went a little way off and bowed himself to the earth; and he prayed again unto the Father, saying:

Father, I thank thee that thou hast purified those whom I have chosen, because of their faith, and I pray for them, and also for them who shall believe on their words, that they may be purified in me, through faith on their words, even as they are purified in me.

Father, I pray not for the world, but for those whom thou hast given me out of the world, because of their faith, that they may be purified in me, that I may be in them as thou, Father, art in me, that we may be one, that I may be glorified in them.

And when Jesus had spoken these words he came again unto his disciples; and behold they did pray steadfastly, without ceasing, unto him; and he did smile upon them again; and behold they were white, even as Jesus.

And it came to pass that he went again a little way off and prayed unto the Father;

- 32 Мөн түүний залбирсан үгсийг хэлээр өгүүлэх аргагүй, бас түүний залбирсан үгс хүмүүнээр бичигдэх аргагүй байлаа.
- 33 Мөн цугласан олон сонссон мөн гэрчилдэг билээ; мөн тэдний зүрх сэтгэл нээлтэй байж мөн тэд түүний залбирсан үгсийг зүрх сэтгэлдээ ойлгосон болой.
- 34 Гэсэн хэдий ч, тэдгээр нь бичигдэх аргагүй бас тэдгээр нь хүмүүнээр хэлэгдэх аргагүй түүний залбирсан үгс нь тийм агуу хийгээд гайхамшигтай байв.
- 35 Мөнхүү улиран тохиох дор Есүс залбирлаа төгсгөл болгоод тэрбээр шавь нартаа дахин ирж, мөн тэдэнд хэлэв: Бүх иудейчүүдийн дунд ийм агуу итгэл би хэзээ ч үзээгүй; иймийн тул тэдний итгэлгүйн учир би тэдэнд ийм агуу гайхамшгуудыг үзүүлж чадаагүй билээ.
- 36 Үнэнээр би та нарт хэлнэ, та нарын үзсэн шиг ийм агуу зүйлийг үзсэн нь тэдний дунд нэг ч үгүй; бас та нарын сонссон шиг ийм агуу зүйлийг тэд сонсоогүй билээ.

And tongue cannot speak the words which he prayed, neither can be written by man the words which he prayed.

And the multitude did hear and do bear record; and their hearts were open and they did understand in their hearts the words which he prayed.

Nevertheless, so great and marvelous were the words which he prayed that they cannot be written, neither can they be uttered by man.

And it came to pass that when Jesus had made an end of praying he came again to the disciples, and said unto them: So great faith have I never seen among all the Jews; wherefore I could not show unto them so great miracles, because of their unbelief.

Verily I say unto you, there are none of them that have seen so great things as ye have seen; neither have they heard so great things as ye have heard.

### 3 Нифай 20

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр цугласан олонд мөн түүнчлэн шавь нартаа тэд залбирахаа зогсохыг зарлиг болгов. Мөн тэрбээр зүрх сэтгэлдээ тэд залбирахаа үл зогсохыг тэдэнд зарлиг болгов.
- 2 Мөн тэрбээр тэд өндийж мөн хөл дээрээ зогсохыг тэдэнд зарлиг болгов. Мөн тэд өндийж мөн хөл дээрээ зогсоцгоов.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр дахин талх хувааж мөн үүнийг адислав, мөн шавь нартаа идүүлэхээр өгөв.
- 4 Мөн тэдгээрийг идэхэд тэд талхыг хувааж, мөн цугласан олонд өгөхийг тэдэнд тэрбээр зарлиглав.
- 5 Мөн тэд цугласан олонд өгөхөд тэрбээр түүнчлэн тэдэнд дарс уулгахаар өгөв, мөн цугласан олонд тэд өгөхийг тэдэнд зарлиглав.
- 6 Эдүгээ шавь нараар нь ч, бас цугласан олноор ямар ч талх бас дарс ч авчрагдсан байсангүй;
- 7 Гэвч тэрбээр үнэхээр тэдэнд идэх талх, мөн түүнчлэн уух дарс өгөв.
- 8 Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Энэ талхыг идэх тэр нь өөрийн бодгалийн төлөө миний биеийг идэх ажгуу; мөн энэ дарсыг уух тэр нь өөрийн бодгальд миний цусыг уух ажгуу; мөн түүний бодгаль хэзээ ч өлсөж, бас цангахгүй, харин ханасан байх болно.
- 9 Эдүгээ, цугласан олон бүгд идэж мөн уухад, болгоогтун, тэд Сүнсээр дүүргэгдэв; мөн тэд нэгэн дуугаар хашгирч, мөн тэд өөрсдийн харсан бас сонссон, Есүсийг магтан дуулав.
- 10 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгд Есүсийг магтан дуулсны дараа, тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун эдүгээ Израилын угсааны үлдэгдэл болох энэ хүмүүсийн талаар Эцэг надад зарлиг болгосон тэрхүү зарлигийг би гүйцээлээ.
- 11 Та нарт миний ярьсныг, мөн Исаиагийн үгс гүйцэлдэх тэр үед юу болохыг хэлснийг та нар санаж байгаа—болгоогтун тэдгээр нь бичигдсэн байгаа, тэдгээр нь та нарт өмнө чинь байна, тиймийн тул тэдгээрийг судал—

### 3 Nephi 20

And it came to pass that he commanded the multitude that they should cease to pray, and also his disciples. And he commanded them that they should not cease to pray in their hearts.

And he commanded them that they should arise and stand up upon their feet. And they arose up and stood upon their feet.

And it came to pass that he brake bread again and blessed it, and gave to the disciples to eat.

And when they had eaten he commanded them that they should break bread, and give unto the multitude.

And when they had given unto the multitude he also gave them wine to drink, and commanded them that they should give unto the multitude.

Now, there had been no bread, neither wine, brought by the disciples, neither by the multitude;

But he truly gave unto them bread to eat, and also wine to drink.

And he said unto them: He that eateth this bread eateth of my body to his soul; and he that drinketh of this wine drinketh of my blood to his soul; and his soul shall never hunger nor thirst, but shall be filled.

Now, when the multitude had all eaten and drunk, behold, they were filled with the Spirit; and they did cry out with one voice, and gave glory to Jesus, whom they both saw and heard.

And it came to pass that when they had all given glory unto Jesus, he said unto them: Behold now I finish the commandment which the Father hath commanded me concerning this people, who are a remnant of the house of Israel.

Ye remember that I spake unto you, and said that when the words of Isaiah should be fulfilled—behold they are written, ye have them before you, therefore search them—

12 Мөн үнэнээр, үнэнээр, би та нарт хэлье, тэдгээр нь гүйцэлдэх үед тэгээд өөрийн хүмүүстэй, Ай Израилын угсаатай Эцэгийн хийсэн гэрээ гүйцэлдэх болно.

13 Мөн тэгээд газрын гадаргуу дээр тархан тараагдах үлдэгдлүүд дорнодоос бас өрнөдөөс, мөн өмнөдөөс бас умардаас цуглуулагдах болно; мөн тэднийг гэтэлгэсэн, Их Эзэн Бурханыхаа мэдлэгт тэд авчрагдах болно.

14 Мөн би та нарт энэ нутгийг та нарын өв болгон өгөхийг Эцэг надад зарлиг болгосон юм.

15 Мөн би та нарт хэлье, тэд миний хүмүүсийг тараасны дараа, тэдний хүлээн авах тэрхүү адислалын дараа хэрэв харийнхан наманчлахгүй аваас—

16 Тэгвэл Иаковын угсааны үлдэгдэл болох та нар, тэдний дунд явах болно; мөн та нар олон байх тэдний дунд байх болно; мөн та нар тэдний дунд хөвчийн амьтдын дундах арслан лугаа адил, хонин сүрэг дундах залуу арслан лугаа адил байх болно хэрэв тэр дундуур нь явах аваас доош дэвсэлж мөн хэдэн хэсэг тасчих ажгуу, мөн хэн ч чөлөөлж чадахгүй.

17 Гар тань өрсөлдөгчийн чинь дээр далайгдаж, мөн бүх дайсан чинь зайлуулагдах болно.

18 Мөн хүмүүн тарианы боодлуудыг саравчинд цуглуулдаг шиг би өөрийн хүмүүсийг нэгтгэн цуглуулах болно.

19 Учир нь Эцэгийн гэрээ хийсэн өөрийн хүмүүсийг би, тийм ээ, би та нарын эврийг чинь төмөр, мөн туурайг чинь гууль болгоно. Мөн та нар олон хүмүүнийг хэдэн хэсэг болгон цохих болно; мөн би Их Эзэний төлөө тэдний баялгийг, мөн бүх дэлхийн Их Эзэний төлөө тэдний эд хөрөнгийг ариулан адислах болно. Мөн болгоогтун, үүнийг хийх тэр нь би билээ.

20 Мөнхүү улиран тохиох дор, Эцэг хэлэв, тэр өдөр миний шударга ёсны илд тэдний дээр далайгаастай байх болно; мөн тэд наманчлахгүй аваас энэ нь тэдний дээр, тийм ээ, бүр харийнханы бүх үндэстнүүдийн дээр буух болно хэмээн Эцэг хэлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор би өөрийн хүмүүсийг, Ай Израилын угсааг төвхнүүлэх болно.

And verily, verily, I say unto you, that when they shall be fulfilled then is the fulfilling of the covenant which the Father hath made unto his people, O house of Israel.

And then shall the remnants, which shall be scattered abroad upon the face of the earth, be gathered in from the east and from the west, and from the south and from the north; and they shall be brought to the knowledge of the Lord their God, who hath redeemed them.

And the Father hath commanded me that I should give unto you this land, for your inheritance.

And I say unto you, that if the Gentiles do not repent after the blessing which they shall receive, after they have scattered my people—

Then shall ye, who are a remnant of the house of Jacob, go forth among them; and ye shall be in the midst of them who shall be many; and ye shall be among them as a lion among the beasts of the forest, and as a young lion among the flocks of sheep, who, if he goeth through both treadeth down and teareth in pieces, and none can deliver.

Thy hand shall be lifted up upon thine adversaries, and all thine enemies shall be cut off.

And I will gather my people together as a man gathereth his sheaves into the floor.

For I will make my people with whom the Father hath covenanted, yea, I will make thy horn iron, and I will make thy hoofs brass. And thou shalt beat in pieces many people; and I will consecrate their gain unto the Lord, and their substance unto the Lord of the whole earth. And behold, I am he who doeth it.

And it shall come to pass, saith the Father, that the sword of my justice shall hang over them at that day; and except they repent it shall fall upon them, saith the Father, yea, even upon all the nations of the Gentiles.

And it shall come to pass that I will establish my people, O house of Israel.

- 22 Мөн болгоогтун, би та нарын өвөг Иаковтай хийсэн гэрээг гүйцэлдүүлэхийн тулд, би энэ хүмүүсийг энэ нутагт төвхнүүлэх болно; мөн энэ нь Шинэ Иерусалим байх болно. Мөн тэнгэрийн хүч энэ хүмүүсийн дунд байх болно; тийм ээ, бүр би та нарын дунд байх болно.
- 23 Болгоогтун, би бол Мосегийн тухайлан ярьж, хэлсэнчлэн: Их Эзэн Бурхан тань та нарт ах дүүсээс тань миний адил бошиглогчийг бий болгох болно; та нарт түүний хэлэх юуг боловч, бүх зүйлийн хувьд түүнийг та нар сонсох болно. Мөнхүү улиран тохиодор тэр бошиглогчийг анхааран сонсохгүй бодгаль болгон, хүмүүсийн дундаас тусгаарлагдах болно.
- 24 Үнэнээр би та нарт хэлье, тийм ээ, мөн Самуелаас эхлээд дараачийн бүх бошиглогчид, ярьсан болгон нь, миний тухай гэрчилсэн билээ.
- 25 Мөн болгоогтун, та нар бол бошиглогчдын хүүхдүүд; мөн та нар бол Израилын угсааных; мөн Абрахамд хэлсэн нь: Мөн чиний үр удмаар дэлхийн бүх үндэстнүүд адислагдах болно хэмээн, та нарын эцэг өвгөдтэй Эцэгийн хийсэн гэрээнийх болой та нар.
- 26 Эцэг та нарын төлөө намайг түрүүнд нь босгосон, мөн та нарын хүн нэг бүрийг алдсуудаас нь эргүүлснээр адислахын тулд намайг илгээсэн; мөн та нар гэрээний хүүхдүүд учраас энэ юм—
- 27 Мөн та нарыг адислагдсаны дараа тэгээд Эцэг, хэлсэн нь: Чиний үр удмаар дамжин дэлхийн бүх үндэстэн адислагдах болно хэмээн Абрахамтай хийсэн гэрээгээ тэрбээр гүйцэлдүүлэх ажгуу—ингэснээр надаар дамжуулан харийнхан дээр Ариун Сүнсийг цутган юүлснээс харийнхан дээрх энэхүү адислал тэднийг бүхнээс дээгүүр хүчирхэг болгосноор, миний хүмүүсийг, Ай Израилын угсааг тараах болно.
- 28 Мөн тэд энэ нутгийн хүмүүст цээрлэл байх болно. Гэсэн хэдий ч, тэд миний сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авсны дараа, тэгээд хэрэв тэд миний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулах аваас би тэдний алдсуудыг өөрсдийнх нь толгой дээр хариулах болно хэмээн Эцэг хэлдэг.

And behold, this people will I establish in this land, unto the fulfilling of the covenant which I made with your father Jacob; and it shall be a New Jerusalem. And the powers of heaven shall be in the midst of this people; yea, even I will be in the midst of you.

Behold, I am he of whom Moses spake, saying: A prophet shall the Lord your God raise up unto you of your brethren, like unto me; him shall ye hear in all things whatsoever he shall say unto you. And it shall come to pass that every soul who will not hear that prophet shall be cut off from among the people.

Verily I say unto you, yea, and all the prophets from Samuel and those that follow after, as many as have spoken, have testified of me.

And behold, ye are the children of the prophets; and ye are of the house of Israel; and ye are of the covenant which the Father made with your fathers, saying unto Abraham: And in thy seed shall all the kindreds of the earth be blessed.

The Father having raised me up unto you first, and sent me to bless you in turning away every one of you from his iniquities; and this because ye are the children of the covenant—

And after that ye were blessed then fulfilleth the Father the covenant which he made with Abraham, saying: In thy seed shall all the kindreds of the earth be blessed—unto the pouring out of the Holy Ghost through me upon the Gentiles, which blessing upon the Gentiles shall make them mighty above all, unto the scattering of my people, O house of Israel.

And they shall be a scourge unto the people of this land. Nevertheless, when they shall have received the fulness of my gospel, then if they shall harden their hearts against me I will return their iniquities upon their own heads, saith the Father.



29 Мөн би өөрийн хүмүүстэй хийсэн тэрхүү гэрээг санах болно; мөн Иерусалимын нутаг болох, Эцэгийн хэлснээр тэдэнд үүрд амлагдсан нутаг болох тэрхүү эцэг өвгөдийнх нь нутгийг тэдний өв болгон дахин өгөх болно хэмээн, өөрийн зохих цагт би тэднийг цуглуулах болно хэмээн би тэдэнтэй гэрээ хийсэн бөлгөө.

30 Мөнхүү улиран тохиох дор сайн мэдээний минь бүрэн байдал тэдэнд номлогдох цаг ирэх болно;

31 Мөн би бол Есүс Христ, Бурханы Хүү гэдэгт тэд надад итгэх болно, мөн миний нэрээр Эцэгт хандан залбирах болно.

32 Тэгээд тэдний харуулууд дуугаа өргөн, мөн нэгэн дуугаар хамтдаа тэд дуулах болно; учир нь тэд нүдээрээ харах болно.

33 Тэгээд Эцэг тэднийг дахин нэгтгэн цуглуулж, мөн тэдний өвлөх нутаг болгон Иерусалимыг тэдэнд өгөх болно.

34 Тэгээд тэд баясан дуу алдах болно—Хамтдаа дуулцгаа, Иерусалимын зэлүүд газрууд та нар; учир нь Эцэг өөрийн хүмүүсийг тайтгаруулж, тэрбээр Иерусалимыг гэтэлгэв.

35 Эцэг бүх үндэстнүүдийн нүдэнд ариун мутраа харуулсан билээ; мөн дэлхийн бүх хязгаарууд Эцэгийн авралыг харах болно; мөн Эцэг бид хоёр нэг юм.

36 Мөн тэгээд бичиглэгдсэн нь: Сэрэгтүн, дахин сэрэгтүн, мөн хүч чадлаа авагтун, Ай Сион; гоёмсог өмсгөлөө өмс, Ай Иерусалим, ариун хот, учир нь цаашид хөвч хөндүүлээгүй мөн цэвэр бус нь чамд дахин үл орох болно гэсэн нь тохион авчрагдах болно.

37 Шороо тоосоо сэгсэр; босоод суу, Ай Иерусалим; хүзүүн дэх хүлээснээсээ өөрийгөө сулла, Ай Сионы боолчлогдогч охин.

38 Учир нь Их Эзэн ийн хэлдэг: Та нар өөрсдийгөө юунаас ч бус худалдсан, мөн та нар мөнгөгүйгээр гэтэлгэгдэх болно.

39 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, миний хүмүүс нэрийг минь мэдэх болно; тийм ээ, тэр өдөр ярих тэр нь би байдгийг тэд мэдэх болно.

And I will remember the covenant which I have made with my people; and I have covenanted with them that I would gather them together in mine own due time, that I would give unto them again the land of their fathers for their inheritance, which is the land of Jerusalem, which is the promised land unto them forever, saith the Father.

And it shall come to pass that the time cometh, when the fulness of my gospel shall be preached unto them;

And they shall believe in me, that I am Jesus Christ, the Son of God, and shall pray unto the Father in my name.

Then shall their watchmen lift up their voice, and with the voice together shall they sing; for they shall see eye to eye.

Then will the Father gather them together again, and give unto them Jerusalem for the land of their inheritance.

Then shall they break forth into joy—Sing together, ye waste places of Jerusalem; for the Father hath comforted his people, he hath redeemed Jerusalem.

The Father hath made bare his holy arm in the eyes of all the nations; and all the ends of the earth shall see the salvation of the Father; and the Father and I are one.

And then shall be brought to pass that which is written: Awake, awake again, and put on thy strength, O Zion; put on thy beautiful garments, O Jerusalem, the holy city, for henceforth there shall no more come into thee the uncircumcised and the unclean.

Shake thyself from the dust; arise, sit down, O Jerusalem; loose thyself from the bands of thy neck, O captive daughter of Zion.

For thus saith the Lord: Ye have sold yourselves for naught, and ye shall be redeemed without money.

Verily, verily, I say unto you, that my people shall know my name; yea, in that day they shall know that I am he that doth speak.

40 Мөн тэгээд тэд хэлэх болно: Баярт мэдээг тэдэнд авчрах; амар амгаланг тунхаглах; сайны тухай баярт мэдээг тэдэнд авчрах; авралыг тунхаглах; Таны Бурхан засаглах болно хэмээн Сионд хэлэх түүний хөл уулсын дээр хичнээн үзэсгэлэнтэй билээ!

41 Мөн тэгээд хашгирах нь: Зайлан одогтун, зайлан одогтун, та нар тэндээс гарагтун, цэвэр бус тэр зүйлд бүү хүр; түүний дундаас та нар гарагтун; Их Эзэний савуудыг тээгч болох та нар цэвэр ариун байгтун.

42 Өөрөөр хэлбэл та нар яарч бас зугтаж гарахгүй; учир нь Их Эзэн та нарын өмнө явна, мөн Израилын Бурхан та нарын ар талын хамгаалалт байх болно.

43 Болгоогтун, үйлчлэгч минь ухаалгаар үйлдэх болно, тэрбээр өргөмжлөгдөн мөн магтагдаж мөн их өндөрт байх болно.

44 Олон нь чамайг хараад гайхан балмагдсан байв— түүний төрх ямар ч хүнийхээс илүүтэй, мөн түүний бие хүмүүний хөвгүүдийнхээс илүүтэй зэрэмдэглэгдсэн билээ—

45 Иймээс тэрбээр олон үндэстнийг шүрших болно; хаад түүний улмаас амаа хамхих болно, учир нь тэдэнд хэлэгдээгүйг тэд үзэх болно; мөн тэдэнд дуулдаагүйг тэд ухаарах.

46 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, эдгээр бүх зүйл, яг Эцэг надад зарлиг болсны дагуу гарцаагүй ирэх болно. Тийнхүү өөрийн хүмүүстэй Эцэгийн хийсэн энэхүү гэрээ гүйцэлдэх болно; мөн тэгээд Иерусалим миний хүмүүсээр дахин эзэмшигдэх болно, мөн энэ нь тэдний өвийн нутаг байх болно.

And then shall they say: How beautiful upon the mountains are the feet of him that bringeth good tidings unto them, that publisheth peace; that bringeth good tidings unto them of good, that publisheth salvation; that saith unto Zion: Thy God reigneth!

And then shall a cry go forth: Depart ye, depart ye, go ye out from thence, touch not that which is unclean; go ye out of the midst of her; be ye clean that bear the vessels of the Lord.

For ye shall not go out with haste nor go by flight; for the Lord will go before you, and the God of Israel shall be your rearward.

Behold, my servant shall deal prudently; he shall be exalted and extolled and be very high.

As many were astonished at thee—his visage was so marred, more than any man, and his form more than the sons of men—

So shall he sprinkle many nations; the kings shall shut their mouths at him, for that which had not been told them shall they see; and that which they had not heard shall they consider.

Verily, verily, I say unto you, all these things shall surely come, even as the Father hath commanded me. Then shall this covenant which the Father hath covenanted with his people be fulfilled; and then shall Jerusalem be inhabited again with my people, and it shall be the land of their inheritance.

### 3 Нифай 21

- 1 Мөн үнэнээр би та нарт хэлнэ, эдгээр зүйл тохиох нь ойртох цагийг та нар мэдэж болохын тулд би та нарт нэгэн тэмдэг өгье—үүнд би өөрийн хүмүүсийг, Ай Израилын угсааг удаан хугацааны тараагдалтаас нь дотогш цуглуулах болно, мөн тэдний дунд өөрийн Сионыг дахин байгуулах болно;
- 2 Мөн болгоогтун, энэ нь та нарт миний тэмдэг болгон өгөх тэр зүйл билээ—учир нь үнэнээр би та нарт хэлнэ, Иаковын угсааны үлдэгдэл болох энэ хүмүүсийн талаар, мөн өөрсдөөр нь тараагдах миний энэ хүмүүсийн талаар тэд мэдэж болохын тулд та нарт миний тунхаглаж байгаа, мөн та нарт миний цаашид ч өөрийн биеэр мөн Эцэгээр та нарт өгөгдөх Ариун Сүнсний хүчээр тунхаглах эдгээр зүйлүүд харийнханд мэдүүлэгдэх тэр үед;
- 3 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, эдгээр зүйлүүд Эцэгээр тэдэнд мэдэгдэх болно, мөн та нарт тэднээс Эцэгээр ирүүлэгдэх тэр үед;
- 4 Учир нь тэд энэ нутагт төвхнүүлэгдэж, мөн Эцэгийн хүчээр чөлөөт хүмүүс болгогдох нь Эцэгийн мэргэн ухаан, өөрийн хүмүүстэй, Ай Израилын угсаатай хийсэн Эцэгийн гэрээ гүйцэлдэж болохын тулд эдгээр зүйлүүд тэднээс та нарын үр удмын үлдэгдэлд ирж болохын тулд буюу;
- 5 Тиймийн тул, эдгээр ажлууд, мөн цаашид та нарын дунд хийгдэх тэрхүү ажлууд харийнханаас, алдсын учир итгэлгүйдээ бууран доройтох тэрхүү үр удамд чинь ирэх тэр үед;
- 6 Учир нь тийн энэ нь харийнханаас ирэх нь Эцэгийн таалал байв, тэрбээр өөрийн хүчийг харийнханд үзүүлж болохын тулд бөлгөө; хэрэв харийнхан зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, тэд миний хүмүүсийн, Ай Израилын угсааны дунд тоологдож болно гэсэн энэхүү шалтгааны улмаас тэд наманчилж мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүртэж мөн сургаалын минь заалтыг мэдэж болох бөлгөө;

### 3 Nephi 21

And verily I say unto you, I give unto you a sign, that ye may know the time when these things shall be about to take place—that I shall gather in, from their long dispersion, my people, O house of Israel, and shall establish again among them my Zion;

And behold, this is the thing which I will give unto you for a sign—for verily I say unto you that when these things which I declare unto you, and which I shall declare unto you hereafter of myself, and by the power of the Holy Ghost which shall be given unto you of the Father, shall be made known unto the Gentiles that they may know concerning this people who are a remnant of the house of Jacob, and concerning this my people who shall be scattered by them;

Verily, verily, I say unto you, when these things shall be made known unto them of the Father, and shall come forth of the Father, from them unto you;

For it is wisdom in the Father that they should be established in this land, and be set up as a free people by the power of the Father, that these things might come forth from them unto a remnant of your seed, that the covenant of the Father may be fulfilled which he hath covenanted with his people, O house of Israel;

Therefore, when these works and the works which shall be wrought among you hereafter shall come forth from the Gentiles, unto your seed which shall dwindle in unbelief because of iniquity;

For thus it behooveth the Father that it should come forth from the Gentiles, that he may show forth his power unto the Gentiles, for this cause that the Gentiles, if they will not harden their hearts, that they may repent and come unto me and be baptized in my name and know of the true points of my doctrine, that they may be numbered among my people, O house of Israel;

- 7 Мөн эдгээр зүйлүүд улиран тохиоход чиний үр удам эдгээр зүйлийг мэдэж эхлэх болно—тэд Израилын угсааных болох хүмүүст түүний хийсэн гэрээг гүйцэлдүүлэхээр Эцэгийн тэрхүү ажил аль хэдийн эхэлснийг тэд мэдэж болохын тулд энэ нь тэдэнд тэмдэг байх болно.
- 8 Мөн тэр өдөр ирэхэд, улиран тохиох дор хаад түүний улмаас амаа хамхих болно; учир нь тэдэнд хэлэгдээгүйг тэд үзэх болно; мөн тэдэнд дуулдаагүйг тэд ухаарах болно.
- 9 Өөрөөр хэлбэл тэр өдөр, миний тусын тулд Эцэг тэдний дундах агуу хийгээд гайхамшигт байх ажлыг үйлдэх болно; мөн хэдийгээр нэгэн хүмүүн үүнийг тэдэнд тунхаглах боловч үүнд итгэхгүй тэд тэдний дунд байх болно.
- 10 Гэвч болгоогтун, миний үйлчлэгчийн амь гарт минь байх болно; тиймийн тул тэдний улмаас тэрбээр зэрэмдэглэгдэх хэдий ч тэд түүнийг гэмтээхгүй болой. Гэсэн хэдий ч би түүнийг эдгээх болно, учир нь миний мэргэн ухаан чөтгөрийн башир аргаас илүү агууг би тэдэнд үзүүлэх болно.
- 11 Тиймийн тул улиран тохиох дор, Эцэг түүнд авчрах хүчийг өгч, харийнханд түүгээр авчруулах, Есүс Христ болох миний үгсэд итгэхгүй хэн боловч, (энэ нь яг Мосегийн хэлсэнчлэн хийгдэх болно) тэд гэрээнийх болох миний хүмүүсийн дундаас тусгаарлагдах болно.
- 12 Мөн Иаковын үлдэгдэл болох миний хүмүүс харийнханы дунд буй, тийм ээ, тэдний дунд хөвчийн амьтдын дундах арслан лугаа адил, хонин сүрэг дундах залуу арслан лугаа адил байх болно, хэрэв тэр дундуур нь явах аваас доош дэвсэлж мөн хэдэн хэсэг тасчина, мөн хэн ч чөлөөлж чадахгүй.
- 13 Гар тань өрсөлдөгчийн чинь дээр далайгдах ажгуу, мөн бүх дайснууд чинь зайлуулагдах болно.
- 14 Тийм ээ, тэд наманчлахгүй аваас харийнханд халаг болог; учир нь улиран тохиох дор тэр өдөр, Эцэг хэлнэ, би морьдыг чинь та нарын дундаас устган зайлуулах болно, мөн би тэрэгнүүдийг чинь устгах болно;
- 15 Мөн би нутгийн чинь хотуудыг тусгаарлана, мөн бүх бэхлэлтүүдийг чинь доош унагах болно;

And when these things come to pass that thy seed shall begin to know these things—it shall be a sign unto them, that they may know that the work of the Father hath already commenced unto the fulfilling of the covenant which he hath made unto the people who are of the house of Israel.

And when that day shall come, it shall come to pass that kings shall shut their mouths; for that which had not been told them shall they see; and that which they had not heard shall they consider.

For in that day, for my sake shall the Father work a work, which shall be a great and a marvelous work among them; and there shall be among them those who will not believe it, although a man shall declare it unto them.

But behold, the life of my servant shall be in my hand; therefore they shall not hurt him, although he shall be marred because of them. Yet I will heal him, for I will show unto them that my wisdom is greater than the cunning of the devil.

Therefore it shall come to pass that whosoever will not believe in my words, who am Jesus Christ, which the Father shall cause him to bring forth unto the Gentiles, and shall give unto him power that he shall bring them forth unto the Gentiles, (it shall be done even as Moses said) they shall be cut off from among my people who are of the covenant.

And my people who are a remnant of Jacob shall be among the Gentiles, yea, in the midst of them as a lion among the beasts of the forest, as a young lion among the flocks of sheep, who, if he go through both treadeth down and teareth in pieces, and none can deliver.

Their hand shall be lifted up upon their adversaries, and all their enemies shall be cut off.

Yea, wo be unto the Gentiles except they repent; for it shall come to pass in that day, saith the Father, that I will cut off thy horses out of the midst of thee, and I will destroy thy chariots;

And I will cut off the cities of thy land, and throw down all thy strongholds;

16 Мөн би чиний нутгаас шулмын аргыг тусгаарлах болно, мөн чамд зөгнөн хэлэгч дахин үгүй байх болно;

17 Чиний зормол шүтээнүүдийг мөн та нарын дундаас босоо шүтээнүүдийг тань би түүнчлэн тусгаарлах болно, мөн та нар өөрийн гарын ажлуудаа цаашид шүтэх ёсгүй;

18 Мөн та нарын дундаас би ойн цоорхойнуудыг чинь суга татах болно; тэрчлэн би хотуудыг чинь устгах болно.

19 Мөнхүү улиран тохиох дор бүх худал, мөн хуурмаг, мөн атаа жөтөө, мөн хэрүүл маргаан, мөн санваараар мэргэших явдал, мөн садар самуун үгүй болох болно.

20 Учир нь улиран тохиох дор, Эцэг хэлсэн нь, тэр өдөр наманчлахгүй мөн Хайрт Хүүд минь ирэхгүй хэнийг боловч, тэднийг би өөрийн хүмүүсийн дундаас, Ай Израилын угсаанаас тусгаарлах болно;

21 Мөн би өс хонзонгоо авч мөн тэдний дээр, бүр буруу номтнуудын дээр лугаа, тэдний сонсоогүй ихээр хилэгнэх болно.

22 Гэвч хэрэв тэд наманчилж мөн миний үгсийг анхааран сонсож, мөн зүрх сэтгэлээ хатууруулахгүй аваас, би өөрийн сүмийг тэдний дунд байгуулах болно, мөн тэд гэрээнд орж мөн энэ нутгийг өөрсдөд нь өв болгон миний өгсөн Иаковын энэхүү үлдэгдлийн дунд тоологдох болно.

23 Мөн тэд миний хүмүүст, Иаковын үлдэгдэлд, мөн түүнчлэн Израилын угсаанаас ирэх болгонд, тэд Шинэ Иерусалим гэж нэрлэгдэх нэгэн хотыг барьж болохын тулд тэд туслах болно.

24 Мөн тэгээд бүх нутгийн гадаргуу дээр тараагдсан тэд Шинэ Иерусалимд цуглан ирж болохын тулд тэд миний хүмүүст туслах болно.

25 Мөн тэгээд тэнгэрийн хүч тэдний дунд бууж ирэх болно; мөн би түүнчлэн дунд нь байх болно.

26 Мөн тэгээд, бүр энэ сайн мэдээ энэ хүмүүсийн үлдэгдлийн дунд номлогдох үед Эцэгийн ажил тэр өдөр эхлэх болно. Үнэнээр би та нарт хэлнэ, тэр өдөр миний хүмүүсийн тараагдсан бүгдийнх нь, тийм ээ, Иерусалимаас Эцэгийн удирдан гаргасан, бүр төөрөлдсөн овгуудын дунд Эцэгийн ажил эхлэх болно.

And I will cut off witchcrafts out of thy land, and thou shalt have no more soothsayers;

Thy graven images I will also cut off, and thy standing images out of the midst of thee, and thou shalt no more worship the works of thy hands;

And I will pluck up thy groves out of the midst of thee; so will I destroy thy cities.

And it shall come to pass that all lyings, and deceivings, and envyings, and strifes, and priestcrafts, and whoredoms, shall be done away.

For it shall come to pass, saith the Father, that at that day whosoever will not repent and come unto my Beloved Son, them will I cut off from among my people, O house of Israel;

And I will execute vengeance and fury upon them, even as upon the heathen, such as they have not heard.

But if they will repent and hearken unto my words, and harden not their hearts, I will establish my church among them, and they shall come in unto the covenant and be numbered among this the remnant of Jacob, unto whom I have given this land for their inheritance;

And they shall assist my people, the remnant of Jacob, and also as many of the house of Israel as shall come, that they may build a city, which shall be called the New Jerusalem.

And then shall they assist my people that they may be gathered in, who are scattered upon all the face of the land, in unto the New Jerusalem.

And then shall the power of heaven come down among them; and I also will be in the midst.

And then shall the work of the Father commence at that day, even when this gospel shall be preached among the remnant of this people. Verily I say unto you, at that day shall the work of the Father commence among all the dispersed of my people, yea, even the tribes which have been lost, which the Father hath led away out of Jerusalem.

- 27 Тийм ээ, тэд миний нэрээр Эцэгийг дуудаж болохын тулд, тэд түүгээр надад ирж болох замыг бэлтгэхээр уг ажил тараагдсан миний бүх хүмүүсийн дунд Эцэгээр эхлүүлэгдэх болно.
- 28 Тийм ээ, мөн тэгээд түүний хүмүүс тэдний өвийн нутаг болох гэртээ түүгээр цуглуулагдаж болох замыг бэлтгэснээр уг ажлыг бүх үндэстнүүдийн дунд Эцэг эхлүүлэх болно.
- 29 Мөн тэд бүх үндэстнүүдээс гарах болно; мөн тэд яарч бас зугтаж гарахгүй, учир нь би тэдний өмнө явах болно, мөн би тэдний ар талын хамгаалалт байх болно хэмээн Эцэг хэлдэг.

Yea, the work shall commence among all the dispersed of my people, with the Father to prepare the way whereby they may come unto me, that they may call on the Father in my name.

Yea, and then shall the work commence, with the Father among all nations in preparing the way whereby his people may be gathered home to the land of their inheritance.

And they shall go out from all nations; and they shall not go out in haste, nor go by flight, for I will go before them, saith the Father, and I will be their rearward.

### 3 Нифай 22

- 1 Мөн тэгээд бичигдсэн нь улиран тохиох болно: Ай дуулцгаа, хүүсэр эмэгтэйчүүд, хүүхэд төрүүлээгүй та нар; дуулж эхэлцгээ, мөн чангаар хашгир, хүүхэд төрүүлэхийн зовлонг үзээгүй та нар; учир нь гэрлээгүй эмэгтэйн хүүхдүүд гэрлэсэн эхнэрийн хүүхдүүдээс илүү олон болно хэмээн Их Эзэн хэлэв.
- 2 Майхныхаа зайг томсгож, мөн сууцныхаа хөшигнүүдийг дэлгэг тэд; биеэ бүү гамна; аргамжаагаа уртасгаж мөн гадсаа бөхлөгтүн;
- 3 Учир нь та баруун гар тийш мөн зүүн тийш хальж, мөн чиний үр удам харийнханыг өвлөж мөн эзгүйрсэн хотуудыг эзэмшигдэхээр болгоно.
- 4 Бүү ай, учир нь чи ичгүүрлэгдэхгүй; бас чи шившиглэгдэх нь үгүй, учир нь чи ичгүүр болгогдохгүй; өөрөөр хэлбэл залуугийнхаа ичингүйрлийг чи мартаж болно, мөн залуугийнхаа шившгийг санахгүй, мөн чи бэлэвсрэлийнхээ тухай шившгийг цаашид санахгүй.
- 5 Учир нь чамайг бий болгогч, чиний эр нөхөр, Түмний Их Эзэн гэдэг нь түүний нэр билээ; мөн чиний Гэтэлгэгч, Израилын Ариун Нэгэн—бүх дэлхийн Бурхан хэмээн тэрбээр нэрлэгдэх болно.
- 6 Учир нь Их Эзэн чамайг залуу насандаа буцаагдсан эхнэр, орхигдсон мөн сэтгэлдээ гашуудсан эмэгтэй хэмээн дуудсан, Бурхан ийн хэлдэг.
- 7 Учир нь чамайг түр зуур л орхисон, харин агуу нигүүлслээр би та нарыг цуглуулах болно.
- 8 Бяцхан хилэгнэлдээ би чамаас түр зуур нүүрээ буруулсан, харин үүрдийн сайхан сэтгэлээр би чамайг нигүүлсэх болно хэмээн Их Эзэн Гэтэлгэгч чинь хэлдэг.
- 9 Энэхэн зуур, миний хувьд Ноагийн ус мэт, учир нь би Ноагийн ус дахин газрыг бүрхэхгүй хэмээн тангарагласан лугаа адил, үүнчлэн би чамд хилэгнэхгүй хэмээн тангарагласан бөлгөө.
- 10 Учир нь уулс одож мөн толгод зөөгдөх болно, харин миний сайхан сэтгэл чамаас одох нь үгүй, бас миний энх амгалангийн гэрээ хөндөгдөхгүй хэмээн таныг нигүүлсэх тэрхүү Их Эзэн хэлдэг.

### 3 Nephi 22

And then shall that which is written come to pass: Sing, O barren, thou that didst not bear; break forth into singing, and cry aloud, thou that didst not travail with child; for more are the children of the desolate than the children of the married wife, saith the Lord.

Enlarge the place of thy tent, and let them stretch forth the curtains of thy habitations; spare not, lengthen thy cords and strengthen thy stakes;

For thou shalt break forth on the right hand and on the left, and thy seed shall inherit the Gentiles and make the desolate cities to be inhabited.

Fear not, for thou shalt not be ashamed; neither be thou confounded, for thou shalt not be put to shame; for thou shalt forget the shame of thy youth, and shalt not remember the reproach of thy youth, and shalt not remember the reproach of thy widowhood any more.

For thy maker, thy husband, the Lord of Hosts is his name; and thy Redeemer, the Holy One of Israel—the God of the whole earth shall he be called.

For the Lord hath called thee as a woman forsaken and grieved in spirit, and a wife of youth, when thou wast refused, saith thy God.

For a small moment have I forsaken thee, but with great mercies will I gather thee.

In a little wrath I hid my face from thee for a moment, but with everlasting kindness will I have mercy on thee, saith the Lord thy Redeemer.

For this, the waters of Noah unto me, for as I have sworn that the waters of Noah should no more go over the earth, so have I sworn that I would not be wroth with thee.

For the mountains shall depart and the hills be removed, but my kindness shall not depart from thee, neither shall the covenant of my peace be removed, saith the Lord that hath mercy on thee.

11 Ай зүдэрсэн, их салхинд ганхан шидэгдсэн, мөн тайтгаруулагдаагүй чи! Болгоогтун, би өнгөт чулуугаар барина, мөн суурийг чинь индранилаар барих болно.

12 Мөн цонхнуудыг чинь би гартаамаар, мөн хаалгануудыг чинь нал эрдэнээр, мөн хэрмийг үнэт чулуугаар хийх болно.

13 Мөн бүх хүүхдүүд чинь Их Эзэнээр сургагдах болно; мөн хүүхдүүдийн чинь амар амгалан агуу байх болно.

14 Зөв шударга байдалд чи байгуулагдах болно; чи айхгүй учир дарлал хавчлагаас хол байх болно, мөн айдсаас хол байна, учир нь чиний дэргэд энэ нь ирэхгүй.

15 Болгоогтун, тэд гарцаагүй чиний эсрэг надаар бус ч нэгдэн цуглах болно; чиний эсрэг нэгдэн цугласан хэн боловч чиний тусын тулд унах болно.

16 Болгоогтун, ажлынхаа багажийг бүтээхээр нүүрсний галыг хөөрөгдөх дархныг бүтээсэн би; мөн устгахын тулд сүйтгэгчийг бүтээсэн бөлгөө би.

17 Чиний эсрэг бүтээгдсэн ямар ч зэвсэг амжилтанд хүрэхгүй; мөн шүүлтэнд чамайг эсэргүүцэн доромжлох хэн болгоныг чи буруушаах болно. Энэ нь Их Эзэний үйлчлэгчдийн өв, мөн тэдний зөв шударга байдал надаас бөлгөө хэмээн Их Эзэн хэлдэг.

O thou afflicted, tossed with tempest, and not comforted! Behold, I will lay thy stones with fair colors, and lay thy foundations with sapphires.

And I will make thy windows of agates, and thy gates of carbuncles, and all thy borders of pleasant stones.

And all thy children shall be taught of the Lord; and great shall be the peace of thy children.

In righteousness shalt thou be established; thou shalt be far from oppression for thou shalt not fear, and from terror for it shall not come near thee.

Behold, they shall surely gather together against thee, not by me; whosoever shall gather together against thee shall fall for thy sake.

Behold, I have created the smith that bloweth the coals in the fire, and that bringeth forth an instrument for his work; and I have created the waster to destroy.

No weapon that is formed against thee shall prosper; and every tongue that shall revile against thee in judgment thou shalt condemn. This is the heritage of the servants of the Lord, and their righteousness is of me, saith the Lord.



### 3 Нифай 23

- 1 Мөн эдүгээ, болгоогтун, би та нарт хэлнэ, та нар эдгээр зүйлийг судалбал зохино. Тийм ээ, та нарт миний өгөх нэг зарлиг нь эдгээрийг хичээнгүйлэн судлах юм; учир нь Исаиагийн үгс агуу билээ.
- 2 Учир нь гарцаагүйгээр Израилын угсаа болох миний хүмүүсийн талаар бүх зүйлийг тэрээр тухайлан ярьсан юм; тиймийн тул тэрбээр түүнчлэн харийнханд ч ярих ёстой нь зайлшгүй билээ.
- 3 Мөн түүний ярьсан бүх зүйл, бүр түүний ярьсан үгсийн дагуу байсаар ирсэн, мөн байх болно.
- 4 Тиймийн тул миний үгсэд анхаарал тавигтун; та нарт миний хэлсэн зүйлийг бичигтүн; мөн Эцэгийн цаг хугацаа хийгээд тааллын дагуу тэдгээр нь харийнханд очих болно.
- 5 Мөн үгсийг минь анхааран сонсож мөн наманчилж бас баптисм хүртэх хэн боловч, чухамхүү тэр нь аврагдах болно. Бошиглогчдыг судал, учир нь эдгээр зүйлийн талаар гэрчлэх нь олон байдаг.
- 6 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр үгсийг хэлээд тэрбээр дахин тэдэнд хэлэв, тэрбээр тэдний хүлээж авсан бүх судруудыг тэдэнд тайлбарласныхаа дараа, тэрбээр тэдэнд хэлэв: Болгоогтун, та нарт байхгүй бусад зарим судруудыг та нар бичээсэй хэмээнэ би.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Нифайд хэлэв: Өөрсдийн хөтөлсөн тэр цэдгийг нааш авчрагтун.
- 8 Мөн Нифай цэдгүүдийг авчирч, мөн тэдгээрийг түүний өмнө тавихад, тэрбээр тэдний зүг хараа бэлчээн мөн хэлэв:
- 9 Үнэнээр би та нарт хэлнэ, би өөрийн үйлчлэгч болох лемен үндэстэн Самуелд, тэрбээр энэ хүмүүст Эцэг өөрийн нэрийг надаар алдаршуулах тэр өдөр олон гэгээнтэн нас барагсдын дундаас босно, мөн олонд үзэгдэнэ, мөн тэдэнд тохинуулах болно гэдгийг гэрчлэхийг зарлиг болгосон билээ. Мөн тэрбээр тэдэнд хэлэв: Тийм байгаагүй гэж үү
- 10 Мөн шавь нар нь түүнд хариулж мөн хэлэв: Тийм ээ, Их Эзэн, үгсийн тань дагуу Самуел бошиглосон, мөн тэдгээр нь бүгд гүйцэлдсэн.

### 3 Nephi 23

And now, behold, I say unto you, that ye ought to search these things. Yea, a commandment I give unto you that ye search these things diligently; for great are the words of Isaiah.

For surely he spake as touching all things concerning my people which are of the house of Israel; therefore it must needs be that he must speak also to the Gentiles.

And all things that he spake have been and shall be, even according to the words which he spake.

Therefore give heed to my words; write the things which I have told you; and according to the time and the will of the Father they shall go forth unto the Gentiles.

And whosoever will hearken unto my words and repenteth and is baptized, the same shall be saved. Search the prophets, for many there be that testify of these things.

And now it came to pass that when Jesus had said these words he said unto them again, after he had expounded all the scriptures unto them which they had received, he said unto them: Behold, other scriptures I would that ye should write, that ye have not.

And it came to pass that he said unto Nephi: Bring forth the record which ye have kept.

And when Nephi had brought forth the records, and laid them before him, he cast his eyes upon them and said:

Verily I say unto you, I commanded my servant Samuel, the Lamanite, that he should testify unto this people, that at the day that the Father should glorify his name in me that there were many saints who should arise from the dead, and should appear unto many, and should minister unto them. And he said unto them: Was it not so?

And his disciples answered him and said: Yea, Lord, Samuel did prophesy according to thy words, and they were all fulfilled.

- 11 Мөн Есүс тэдэнд хэлэв: Олон гэгээнтэн босож мөн олонд үзэгдэж мөн тэдэнд тохинуулсныг, энэ зүйлийг та нар яахан үл бичсэн билээ
- 12 Мөнхүү улиран тохиох дор Нифай энэ зүйл бичигдээгүйг санах.
- 13 Мөнхүү улиран тохиох дор Есүс үүнийг бичсүгэй хэмээн зарлиг болов; тиймийн тул энэ нь түүний зарлиг болгосончлон бичиглэгдэв.
- 14 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс тэдний бичсэн бүх судруудыг нэгтгэн тайлбарласны дараа, өөрийн тайлбарласан зүйлийг тэд заахыг тэрбээр тэдэнд зарлиг болгов.

And Jesus said unto them: How be it that ye have not written this thing, that many saints did arise and appear unto many and did minister unto them?

And it came to pass that Nephi remembered that this thing had not been written.

And it came to pass that Jesus commanded that it should be written; therefore it was written according as he commanded.

And now it came to pass that when Jesus had expounded all the scriptures in one, which they had written, he commanded them that they should teach the things which he had expounded unto them.

### 3 Нифай 24

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Малахид Эцэгийн өгсөн, тэрбээр өөрөө тэдэнд хэлэх үгсийг бичихийг тэдэнд зарлиглав. Мөнхүү улиран тохиох дор тэдгээр нь бичигдсэний дараа тэрбээр тэдгээрийг тайлбарлав. Мөн эдгээр нь тэдэнд түүний хэлсэн үгс билээ, хэлсэн нь: Эцэг тийн Малахид хэлж өгүүлсэн нь—Болгоогтун, би өөрийн элчийг илгээх болно, мөн тэрбээр миний өмнө замыг бэлтгэж, мөн та нарын эрэлхийлэх тэрхүү Их Эзэн, бүр түүнд баясах та нарын гэрээний тэрхүү элч гэнэт өөрийн ариун сүмд ирэх болно; болгоогтун, тэрбээр ирэх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг ажгуу.
- 2 Гэвч хэн түүний ирэлтийн өдрийг тэсвэрлэж, мөн түүнийг хүрч ирэхэд хэн зогсоогоороо үлдэж чадах билээ? Учир нь тэрбээр хайлагчийн гал лугаа адил, мөн хувцас угаагчийн саван лугаа адил болой.
- 3 Мөн тэрбээр мөнгө хайлагч мөн цэвэршүүлэгч лугаа адил суух болно, мөн тэд Их Эзэнд зөв шударга байдалд өргөл өргөж болохын тулд тэр Левийн хөвгүүдийг цэвэршүүлнэ, мөн тэднийг алт болоод мөнгө лугаа адил ангижруулан цэвэршүүлэх болно болой.
- 4 Тэгээд Иудейн мөн Иерусалимын өргөл Их Эзэнд, эртний өдрүүдийнх шиг, мөн урьдын жилүүдийнх шиг таалагдах болно.
- 5 Мөн би та нарын дэргэд шүүхээр ирэх болно; мөн би илбэ шидтэнгүүдийн эсрэг, мөн садар самууныг үйлдэгчдийн эсрэг, мөн хуурамч ам тангараг тавигчдын эсрэг, мөн хөлслөгчдийнхөө цалин хөлсөөр нь дарлан хавчдаг, бэлэвсэн мөн эцэггүйг дарлан, мөн харь нэгэнд туслахаас татгалзан, мөн надаас үл эмээдэг тэдний эсрэг би шуурхай гэрч байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.
- 6 Учир нь би бол Их Эзэн, би өөрчлөгддөггүй; тиймийн тул Иаковын хөвгүүд та нар шатаагдаагүй.
- 7 Бүр эцэг өвгөдийнхөө өдрүүдээс та нар ёслолуудаас минь зайцан явсан, мөн тэдгээрийг дагаагүй. Надад эргэж ир мөн би та нарт эргэж очих болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг. Гэвч: Бид хэрхэн эргэж очих билээ? хэмээн та нар хэлдэг.

### 3 Nephi 24

And it came to pass that he commanded them that they should write the words which the Father had given unto Malachi, which he should tell unto them. And it came to pass that after they were written he expounded them. And these are the words which he did tell unto them, saying: Thus said the Father unto Malachi—Behold, I will send my messenger, and he shall prepare the way before me, and the Lord whom ye seek shall suddenly come to his temple, even the messenger of the covenant, whom ye delight in; behold, he shall come, saith the Lord of Hosts.

But who may abide the day of his coming, and who shall stand when he appeareth? For he is like a refiner's fire, and like fuller's soap.

And he shall sit as a refiner and purifier of silver; and he shall purify the sons of Levi, and purge them as gold and silver, that they may offer unto the Lord an offering in righteousness.

Then shall the offering of Judah and Jerusalem be pleasant unto the Lord, as in the days of old, and as in former years.

And I will come near to you to judgment; and I will be a swift witness against the sorcerers, and against the adulterers, and against false swearers, and against those that oppress the hireling in his wages, the widow and the fatherless, and that turn aside the stranger, and fear not me, saith the Lord of Hosts.

For I am the Lord, I change not; therefore ye sons of Jacob are not consumed.

Even from the days of your fathers ye are gone away from mine ordinances, and have not kept them. Return unto me and I will return unto you, saith the Lord of Hosts. But ye say: Wherein shall we return?

8 Хүмүүн Бурханыг дээрэмдэх үү? Гэсэн ч та нар намайг дээрэмдсэн билээ. Гэвч: Бид хэрхэн таныг дээрэмдэв? хэмээн та нар хэлдэг. Аравны нэг болон өргөлүүдээр.

9 Та нар зүхлээр зүхэгдсэн, учир нь та нар, бүр энэ бүхэл үндэстэн намайг дээрэмдсэн билээ.

10 Өргөөнд минь хүнс байж болохын тулд та нар аравны нэг болох бүхнийг агуулахад авчирцгаа; мөн эдүгээ, үүнийг хүлээн авах хангалттай зай байхгүй болтол би тэнгэрийн цонхнуудыг нээж, мөн та нарын дээр адислалыг цутгах эсэхийг үүгээр намайг сорь хэмээн Түмний Их Эзэн хэллээ.

11 Мөн би та нарын тусын тулд залгигчийг зэмлэх болно, мөн тэрбээр газар дахь үр жимсийг тань устгахгүй; бас мөчир чинь ч цагаас өмнө жимсээ талбайд унагахгүй хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

12 Мөн бүх үндэстэн та нарыг адислагдсан хэмээн дуудах болно, учир нь та нар таатай сайхан нутаг байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.

13 Та нарын үгс миний эсрэг хүчтэй байсан хэмээн Их Эзэн хэлдэг. Гэсэн ч та нар хэлдэг: Таны эсрэг бид юу ярьсан билээ

14 Та нар хэлдэг: Бурханд үйлчлэх нь хоосон, мөн түүний ёслолуудыг дагалаа гээд мөн бид Түмний Их Эзэний өмнө гашуудал дүүрэн алхсан гээд ямар ашиг байх билээ

15 Мөн эдүгээ бид бардам тэднийг аз жаргалтай хэмээдэг; тийм ээ, тэд ёс бусыг үйлддэг, тэд дэгжсэн; тийм ээ, Бурханыг өдөөх тэд бүр чөлөөлөгдсөн байдаг.

16 Тэгээд Их Эзэнээс эмээх тэд ойр ойрхон нэг нэгэнтэйгээ ярьж мөн Их Эзэн анхаарч мөн сонссон бөлгөө; мөн Их Эзэнээс эмээх мөн түүний нэрийг бишрэн бодох тэдний төлөө дурсамжийн ном түүний өмнө бичигдсэн бөлгөө.

17 Мөн би үнэт чулуунуудаа цуглуулах тэр өдөр тэд минийх байх болно; мөн өөрт нь үйлчлэх хүүгээ энэрэх хүмүүний адил би тэднийг энэрэн хэлтрүүлэх болно гэж Түмний Их Эзэн хэлдэг.

18 Тэгээд та нар эргэж ирэн мөн зөв шударгыг үйлдэгчид мөн ёс бусыг үйлдэгчдийн хоорондох, Бурханд үйлчилдэг мөн түүнд үйлчилдэггүй тэдний хоорондох ялгааг олж харах болно.

Will a man rob God? Yet ye have robbed me. But ye say: Wherein have we robbed thee? In tithes and offerings.

Ye are cursed with a curse, for ye have robbed me, even this whole nation.

Bring ye all the tithes into the storehouse, that there may be meat in my house; and prove me now herewith, saith the Lord of Hosts, if I will not open you the windows of heaven, and pour you out a blessing that there shall not be room enough to receive it.

And I will rebuke the devourer for your sakes, and he shall not destroy the fruits of your ground; neither shall your vine cast her fruit before the time in the fields, saith the Lord of Hosts.

And all nations shall call you blessed, for ye shall be a delightsome land, saith the Lord of Hosts.

Your words have been stout against me, saith the Lord. Yet ye say: What have we spoken against thee?

Ye have said: It is vain to serve God, and what doth it profit that we have kept his ordinances and that we have walked mournfully before the Lord of Hosts?

And now we call the proud happy; yea, they that work wickedness are set up; yea, they that tempt God are even delivered.

Then they that feared the Lord spake often one to another, and the Lord hearkened and heard; and a book of remembrance was written before him for them that feared the Lord, and that thought upon his name.

And they shall be mine, saith the Lord of Hosts, in that day when I make up my jewels; and I will spare them as a man spareth his own son that serveth him.

Then shall ye return and discern between the righteous and the wicked, between him that serveth God and him that serveth him not.

### 3 Нифай 25

- 1 Учир нь болгоогтун, зуухандшатах лугаа адил тийм өдөр ирнэ; мөн бардамнагчид, бүгд, тийм ээ, мөн ёс бусыг үйлдэх тэд бүгд, талбайд хаягдсан сүрэл лугаа адил байх болно; мөн ирэх тэр өдөр тэднийг шатаах болно, энэ нь тэдгээрийн үндсийг ч бас мөчрийг нь ч эс үлдээх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.
- 2 Гэвч нэрнээс минь эмээх та нарт, Зөв Шударгын Хүү жигүүртээ эдгээх чадлыг эзэмдэн босох болно; мөн та нар одож мөн пүнзэнд байгаа тугалууд лугаа адил өсөх болно.
- 3 Мөн та нар ёс бусыг үйлдэгчдийг доош дэвслэх болно; учир нь би үүнийг үйлдэх тэр өдөр тэд хөлийн чинь улан доорхи нурам чандруу байх болно хэмээн Түмний Их Эзэн хэлдэг.
- 4 Бүх Израилын төлөө Хорebt дүрмүүд болоод тогтоолуудын хамт түүнд миний зарлиг болгосон, миний үйлчлэгч Мосегийн хуулийг санагтун, та нар.
- 5 Болгоогтун, Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр ирэхийн өмнө би та нарт бошиглогч Елиаг илгээх болно;
- 6 Мөн би ирж мөн дэлхийг зүхлээр цохихгүйн тулд тэрбээр эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүдэд нь, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлийг эцгүүдэд нь эргүүлэх болно.

### 3 Nephi 25

For behold, the day cometh that shall burn as an oven; and all the proud, yea, and all that do wickedly, shall be stubble; and the day that cometh shall burn them up, saith the Lord of Hosts, that it shall leave them neither root nor branch.

But unto you that fear my name, shall the Son of Righteousness arise with healing in his wings; and ye shall go forth and grow up as calves in the stall.

And ye shall tread down the wicked; for they shall be ashes under the soles of your feet in the day that I shall do this, saith the Lord of Hosts.

Remember ye the law of Moses, my servant, which I commanded unto him in Horeb for all Israel, with the statutes and judgments.

Behold, I will send you Elijah the prophet before the coming of the great and dreadful day of the Lord;

And he shall turn the heart of the fathers to the children, and the heart of the children to their fathers, lest I come and smite the earth with a curse.

### 3 Нифай 26

- 1 Мөн эдүгээ улиран тохиох дор Есүс эдгээр зүйлийг хэлээд тэрбээр цугласан олонд тэдгээрийг тайлбарлав; мөн тэрбээр тэдэнд, агуу их бас бяцхан аль алиныг нь бүх зүйлийг тайлбарласан болой.
- 2 Мөн тэрбээр хэлэв: Та нарт өөрсдөд тань байгаагүй эдгээр судруудыг би та нарт өгөхийг Эцэг надад зарлиг болгосон бөлгөө; учир нь тэдгээр нь ирээдүйн үеүдэд өгөгдөх болно гэсэн нь түүний мэргэн ухаан байв.
- 3 Мөн тэрбээр бүх зүйлийг тайлбарлав, бүр эхлээс тэрбээр алдар суундаа ирэх тэр цагийг хүртэл буюу—тийм ээ, бүр газрын гадаргуу дээр ирэх тэр бүх зүйлийг, бүр бичил хэсгүүд ч гал халуунд хайлах, мөн газар дэлхий хуйлмал бичиг лугаа адил хуйлагдаж, мөн тэнгэр хийгээд газар үгүй болох хүртэл;
- 4 Мөн бүр бүх хүмүүс, мөн бүх ястан, мөн бүх үндэстэн мөн хэлтнүүд Бурханы өмнө өөрсдийн үйлүүдээр, тэдгээр нь сайн эсвээс хилэнцэт эсэхээр шүүгдэхээр зогсох тэрхүү агуу хийгээд эцсийн өдөр хүртэл—
- 5 Хэрэв тэдгээр нь сайн аваас, үүрдийн амьдралын амилуулалтанд; мөн хэрэв тэдгээр нь хилэнцэт бөгөөс, ялын амилуулалтанд байна; эн зэрэгцээ байх тэр, нэг нь нэг гарт мөн нөгөө нь нөгөө гар талд, дэлхийн эхлэлээс өмнө байсан Христ дэх нигүүлслийн, мөн шударга ёсны, мөн ариун чанарын дагуу байх бөлгөө.
- 6 Мөн эдүгээ уг хүмүүст Есүсийн үнэхээр сургасан тэр зүйлүүдийн бүр зууны нэг хэсэг нь ч энэ номонд бичигдэх аргагүй;
- 7 Гэвч болгоогтун Нифайн ялтсууд уг хүмүүст түүний заасан зүйлүүдийн өөр хэсгийг агуулдаг болой.
- 8 Мөн эдгээр зүйлийг, уг хүмүүст түүний заасан зүйлүүдийн багахан хэсгийг би бичиглэсэн; мөн тэдгээр нь Есүсийн ярьсан үгсийн дагуу, энэ хүмүүст харийнханаас дахин авчрагдаж болно гэсэн зорилготойгоор тэдгээрийг бичиглэсэн бөлгөө би.
- 9 Мөн эхэлж авах нь зайлшгүй болох үүнийг итгэл нь соригдохын тулд тэд хүлээн аваад, мөн хэрэв тэд эдгээр зүйлд итгэх аваас, тэгвэл агуу зүйлүүд тэдэнд үзүүлэгдэх болно.

### 3 Nephi 26

And now it came to pass that when Jesus had told these things he expounded them unto the multitude; and he did expound all things unto them, both great and small.

And he saith: These scriptures, which ye had not with you, the Father commanded that I should give unto you; for it was wisdom in him that they should be given unto future generations.

And he did expound all things, even from the beginning until the time that he should come in his glory—yea, even all things which should come upon the face of the earth, even until the elements should melt with fervent heat, and the earth should be wrapt together as a scroll, and the heavens and the earth should pass away;

And even unto the great and last day, when all people, and all kindreds, and all nations and tongues shall stand before God, to be judged of their works, whether they be good or whether they be evil—

If they be good, to the resurrection of everlasting life; and if they be evil, to the resurrection of damnation; being on a parallel, the one on the one hand and the other on the other hand, according to the mercy, and the justice, and the holiness which is in Christ, who was before the world began.

And now there cannot be written in this book even a hundredth part of the things which Jesus did truly teach unto the people;

But behold the plates of Nephi do contain the more part of the things which he taught the people.

And these things have I written, which are a lesser part of the things which he taught the people; and I have written them to the intent that they may be brought again unto this people, from the Gentiles, according to the words which Jesus hath spoken.

And when they shall have received this, which is expedient that they should have first, to try their faith, and if it shall so be that they shall believe these things then shall the greater things be made manifest unto them.

- 10 Мөн хэрэв эдгээр зүйлүүдэд тэд итгэхгүй аваас, тэгвэл тэднийг буруутгах буруушаалт болон илүү агуу зүйлүүд тэднээс далдлагдах болно.
- 11 Болгоогтун, Нифайн ялтсууд дээр сийлбэрлэгдсэн бүгдийг би бичих гэж байв, гэвч Их Эзэн үүнийг хориглож, хэлсэн нь: Би өөрийн хүмүүсийн итгэлийг сорих болно.
- 12 Тиймийн тул би, Мормон, Их Эзэнээс надад зарлиг болгогдсон зүйлийг бичсэн бөлгөө. Мөн эдүгээ би, Мормон, үгсээ төгсгөл болгон, мөн надад зарлиг болгогдсон зүйлийг бичихээ үргэлжлүүлэе.
- 13 Тиймийн тул, Их Эзэн гурван өдрийн турш уг хүмүүст үнэхээр заасныг та нар болгоогоосой хэмээнэ би; мөн тэгснийхээ дараа тэрбээр өөрийгөө тэдэнд ойр ойрхон үзүүлсэн, мөн ойр ойрхон талх хувааж, мөн үүнийг адисалж, мөн үүнийг тэдэнд өгсөн болой.
- 14 Мөнхүү улиран тохиох дор тухайлан яригдсан цугласан олны хүүхдүүдэд тэрбээр зааж мөн тохиноулж, мөн тэрбээр тэдний хэлийг хурц болгон, мөн тэд агуу хийгээд гайхамшигт зүйлийг, бүр түүний хүмүүст илчилснээс ч илүү агуу эцгүүддээ ярьсан ажгуу; мөн тэд ярьж чадахын тулд тэдний хэлийг тэрбээр хурцалсан бөлгөө.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэр тэнгэрт дээшлэн одсоныхоо—хоёр дахь удаагаа тэдэнд өөрийгөө үзүүлж, мөн тэдний өвдсөнийг мөн доголонт эдгээж, мөн тэдний хараагүйнх нь нүдийг нээж, мөн дүлийнх нь чихний бөглөөсийг гаргаж, мөн бүр төрөл бүрийн эдгээлтийг тэдний дунд үйлдэж, мөн хүмүүнийг нас барагсдын дундаас босгож, мөн тэдэнд өөрийн хүчийг үзүүлснийхээ дараа Эцэгт очив, мөн Эцэгт дээшлэн одсоныхоо дараа болой—
- 16 Болгоогтун, улиран тохиох дор маргааш нь олон түмэн нэгдэн цугларцгааж, мөн тэд эдгээр хүүхдүүдийг харж мөн сонсоцгоов; тийм ээ, бүр нялхас ч амаа нээж мөн гайхамшигт зүйлийг хэлэв; мөн тэдний хэлсэн зүйлийг ямар ч хүмүүн тэдгээрийг бичих нь хориглогдов.

And if it so be that they will not believe these things, then shall the greater things be withheld from them, unto their condemnation.

Behold, I was about to write them, all which were engraven upon the plates of Nephi, but the Lord forbade it, saying: I will try the faith of my people.

Therefore I, Mormon, do write the things which have been commanded me of the Lord. And now I, Mormon, make an end of my sayings, and proceed to write the things which have been commanded me.

Therefore, I would that ye should behold that the Lord truly did teach the people, for the space of three days; and after that he did show himself unto them oft, and did break bread oft, and bless it, and give it unto them.

And it came to pass that he did teach and minister unto the children of the multitude of whom hath been spoken, and he did loose their tongues, and they did speak unto their fathers great and marvelous things, even greater than he had revealed unto the people; and he loosed their tongues that they could utter.

And it came to pass that after he had ascended into heaven—the second time that he showed himself unto them, and had gone unto the Father, after having healed all their sick, and their lame, and opened the eyes of their blind and unstopped the ears of the deaf, and even had done all manner of cures among them, and raised a man from the dead, and had shown forth his power unto them, and had ascended unto the Father—

Behold, it came to pass on the morrow that the multitude gathered themselves together, and they both saw and heard these children; yea, even babes did open their mouths and utter marvelous things; and the things which they did utter were forbidden that there should not any man write them.

17 Мөнхүү улиран тохиох дор Есүсийн сонгосон шавь нар тэр цагаас ирсэн болгонд баптисм хүртээж мөн тэдэнд зааж эхлэв; мөн Есүсийн нэрээр баптисм хүртсэн болгон нь Ариун Сүнсээр дүүргэгдэв.

18 Мөн тэдний олон нь бичигдэх нь зөвшөөрөгдөөгүй, үгээр хэлшгүй зүйлийг үзэж мөн сонсов.

19 Мөн тэд нэг нэгэндээ зааж мөн тохинуулсан болой; мөн тэд бүх зүйлийг дундаа нийтээр эзэмшиж, хүн бүр нэг нэгэндээ шударгаар хандаж байв.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд яг Есүсийн тэдэнд зарлиг болгосончлон бүх зүйлийг ёсчлон хийжээ.

21 Мөн Есүсийн нэрээр баптисм хүртсэн тэд Христийн сүм хэмээн нэрлэгдэв.

And it came to pass that the disciples whom Jesus had chosen began from that time forth to baptize and to teach as many as did come unto them; and as many as were baptized in the name of Jesus were filled with the Holy Ghost.

And many of them saw and heard unspeakable things, which are not lawful to be written.

And they taught, and did minister one to another; and they had all things common among them, every man dealing justly, one with another.

And it came to pass that they did do all things even as Jesus had commanded them.

And they who were baptized in the name of Jesus were called the church of Christ.



### 3 Нифай 27

- 1 Мөнхүү улиран тохиох дор Есүсийн шавь нар аялж мөн өөрсдийн сонссон мөн үзсэн зүйлийг номлож, мөн Есүсийн нэрээр баптисм хүртээж байх үед, улиран тохиох дор шавь нар нь нэгдэн цугларцгааж мөн хүчирхэг залбирал мөн мацаг барилтад нэгдэв.
- 2 Мөн Есүс өөрийгөө дахин тэдэнд үзүүлэв, учир нь тэд Эцэгт хандан түүний нэрээр залбирч байсан ажээ; мөн Есүс ирж мөн тэдний дунд зогсоод, мөн тэдэнд хэлэв: Та нарт намайг юу өгөөсэй хэмээн та нар хүснэв
- 3 Мөн тэд түүнд хэлэв: Их Эзэн, энэ сүмийг ямар нэрээр нэрлэхийг бидэнд хэлээсэй хэмээн бид та наас хүсч байна; учир нь энэ хэргийн талаар хүмүүсийн дунд арцалдаан байна.
- 4 Мөн Их Эзэн тэдэнд хэлэв: Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, хүмүүс яагаад энэ хэргийн учир бувтналдан мөн арцалдах болов
- 5 Миний нэр болох, Христийн нэрийг та нар өөрсдийн дээр авах ёстой хэмээсэн, судруудыг тэд уншаагүй гэж үү? Учир нь энэ нэрээр та нар эцсийн өдөр дуудагдах болно;
- 6 Мөн өөрийн дээр миний нэрийг авсан, мөн эцсээ хүртэл тэвчих хэн боловч, чухамхүү тэр нь эцсийн өдөр аврагдах болно.
- 7 Тиймийн тул, та нар юуг ч үйлдсэн, үүнийгээ миний нэрээр үйлдэх болно; тиймийн тул та нар сүмийг миний нэрээр нэрлэх болно; мөн тэрбээр миний тусын тулд сүмийг адислахын тулд та нар миний нэрээр Эцэгт хандах болно.
- 8 Мөн энэ нь миний нэрээр нэрлэгдэхгүй аваас яахан миний сүм байх билээ? Учир нь хэрэв сүм Мосегийн нэрээр нэрлэгдсэн байвал энэ нь Мосегийн сүм; эсвэл хэрэв энэ нь хүмүүний нэрээр нэрлэгдсэн байвал уг сүм нь хүмүүний сүм байна; харин энэ нь миний нэрээр нэрлэгдвэл, хэрэв тэд миний сайн мэдээн дээр тулгуурлах аваас, тэгвэл энэ нь миний сүм мөн.

### 3 Nephi 27

And it came to pass that as the disciples of Jesus were journeying and were preaching the things which they had both heard and seen, and were baptizing in the name of Jesus, it came to pass that the disciples were gathered together and were united in mighty prayer and fasting.

And Jesus again showed himself unto them, for they were praying unto the Father in his name; and Jesus came and stood in the midst of them, and said unto them: What will ye that I shall give unto you?

And they said unto him: Lord, we will that thou wouldst tell us the name whereby we shall call this church; for there are disputations among the people concerning this matter.

And the Lord said unto them: Verily, verily, I say unto you, why is it that the people should murmur and dispute because of this thing?

Have they not read the scriptures, which say ye must take upon you the name of Christ, which is my name? For by this name shall ye be called at the last day;

And whoso taketh upon him my name, and endureth to the end, the same shall be saved at the last day.

Therefore, whatsoever ye shall do, ye shall do it in my name; therefore ye shall call the church in my name; and ye shall call upon the Father in my name that he will bless the church for my sake.

And how be it my church save it be called in my name? For if a church be called in Moses' name then it be Moses' church; or if it be called in the name of a man then it be the church of a man; but if it be called in my name then it is my church, if it so be that they are built upon my gospel.

- 9 Үнэнээр би та нарт хэлнэ, та нар миний сайн мэдээн дээр тулгуурласан; тиймийн тул та нар нэрлэсэн бүхнээ миний нэрээр нэрлэх болно; тиймийн тул хэрэв та нар уг сүмийн төлөө Эцэгт хандан гуйж, хэрэв энэ нь миний нэрээр аваас Эцэг та нарыг сонсох болно;
- 10 Мөн хэрэв уг сүм нь миний сайн мэдээн дээр тулгуурласан аваас тэгвэл Эцэг үүний дотор өөрийнхөө ажлуудыг үзүүлэх болно.
- 11 Гэвч хэрэв энэ нь миний сайн мэдээн дээр тулгуурлаагүй, мөн хүмүүний ажлууд дээр, эсвээс чөтгөрийн ажлууд дээр тулгуурласан аваас, үнэнээр би та нарт хэлнэ, тэд өөрсдийн ажлууддаа түр зуур л баясна, мөн төдөлгүй төгсгөл ирэхэд, мөн тэд тас цавчигдан мөн эргэж гарах аргагүй галд хаягдах болно.
- 12 Учир нь үйлүүд нь тэднийг дагадаг, өөрөөр хэлбэл тэдний тас цавчигдах нь тэдний үйлүүдийн улмаас болой; тиймийн тул та нарт миний хэлсэн зүйлийг санагтун.
- 13 Болгоогтун би өөрийн сайн мэдээг та нарт өгсөн, мөн энэ бол та нарт миний өгсөн тэр сайн мэдээ— Эцэг минь намайг илгээсний учир би Эцэгийнхээ тааллыг гүйцэлдүүлэхээр дэлхийд ирсэн билээ.
- 14 Мөн би загалмай дээр өргөгдөж болохын тулд, би загалмай дээр өргөгдсөний дараа, би бүх хүмүүнийг өөртөө татаж болохын тулд, би хүмүүнээр өргөгдсөний адилаар хүмүүн миний өмнө зогсож, өөрсдийн үйлүүдээр тэд сайн эсвэл хилэнцэт байх эсэхээрээ шүүгдэхээр Эцэгээр өргөгдөхийн тулд Эцэг минь намайг илгээсэн бөлгөө;
- 15 Мөн энэ шалтгааны учир би өргөгдөв; тиймийн тул тэд өөрсдийн үйлүүдийн дагуу шүүгдэж болохын тулд Эцэгийн хүчний дагуу би бүх хүмүүнийг өөртөө татах болно.
- 16 Мөнхүү улиран тохиох дор, наманчилж мөн миний нэрэнд баптисм хүртэх хэн боловч дүүргэгдэх болно; мөн хэрэв тэр эцсээ хүртэл тэвчих аваас, болгоогтун, би дэлхийг шүүхээр зогсох тэр өдөр Эцэгийнхээ өмнө би түүний гэмгүйг үнэлэх болно.
- 17 Мөн эцсээ хүртэл үл тэвчсэн тэрбээр, чухамхүү тэр нь түүнчлэн тас цавчигдаж мөн тэд тэндээс дахин эргэж ирэх аргагүй галд хаягдах тэр нь мөн, учир юун гэвэл Эцэгийн шударга ёсных юм.

Verily I say unto you, that ye are built upon my gospel; therefore ye shall call whatsoever things ye do call, in my name; therefore if ye call upon the Father, for the church, if it be in my name the Father will hear you;

And if it so be that the church is built upon my gospel then will the Father show forth his own works in it.

But if it be not built upon my gospel, and is built upon the works of men, or upon the works of the devil, verily I say unto you they have joy in their works for a season, and by and by the end cometh, and they are hewn down and cast into the fire, from whence there is no return.

For their works do follow them, for it is because of their works that they are hewn down; therefore remember the things that I have told you.

Behold I have given unto you my gospel, and this is the gospel which I have given unto you—that I came into the world to do the will of my Father, because my Father sent me.

And my Father sent me that I might be lifted up upon the cross; and after that I had been lifted up upon the cross, that I might draw all men unto me, that as I have been lifted up by men even so should men be lifted up by the Father, to stand before me, to be judged of their works, whether they be good or whether they be evil—

And for this cause have I been lifted up; therefore, according to the power of the Father I will draw all men unto me, that they may be judged according to their works.

And it shall come to pass, that whoso repenteth and is baptized in my name shall be filled; and if he endureth to the end, behold, him will I hold guiltless before my Father at that day when I shall stand to judge the world.

And he that endureth not unto the end, the same is he that is also hewn down and cast into the fire, from whence they can no more return, because of the justice of the Father.

- 18 Мөн хүмүүний үрсэд түүний өгсөн тэр үг нь энэ юм. Мөн энэхүү шалтгааны учир тэрээр өгсөн үгсээ гүйцэлдүүлнэ, мөн тэрбээр худал хэлдэггүй, харин өөрийн бүх үгсийг гүйцэлдүүлдэг.
- 19 Мөн ямар ч цэвэр бус зүйл түүний хаант улсад орж чадахгүй; тиймийн тул өөрсдийн итгэл, мөн өөрсдийн бүх нүглийн наманчлал, мөн төгсгөл хүртэлх өөрсдийнх нь үнэнч шударга байдлын учир миний цусанд өөрсдийн өмсгөлийг угаасан тэднээс бусад юу ч түүний амралтад орохгүй.
- 20 Эдүгээ уг зарлиг нь энэ болой: Ариун Сүнсний хүлээн авалтаар та нар ариусагдаж болохын тулд, эцсийн өдөр та нар миний өмнө толбогүйгээр зогсож болохын тулд наманчлагтун, мөн надад ирэгтүн мөн миний нэрээр баптисм хүртэгтүн, газар дэлхийн хязгаарууд та нар бүгд.
- 21 Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний сайн мэдээ; мөн миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; учир нь миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно; учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно;
- 22 Тиймийн тул, хэрэв та нар эдгээр зүйлийг хийх аваас та нар адислагдана, учир нь та нар эцсийн өдөр өргөгдөх болно.
- 23 Хориглогдсон тэдгээрээс бусад, өөрсдийн үзсэн мөн дуулсан тэр зүйлүүдээ бичигтүн.
- 24 Бүр байсан тэрний бичигдсэн лугаа адил, энэ хүмүүсийн байх тэр ажлуудыг бичигтүн.
- 25 Учир нь болгоогтун, тэдний ажлууд тэдгээрээр хүмүүнд мэдэгдэхийн учир бичигдсэн байгаа, мөн бичигдэх тэр номнуудаас энэ хүмүүс шүүгдэх болно.
- 26 Мөн болгоогтун, бүх зүйл Эцэгээр бичигдсэн юм; тиймийн тул бичигдэх тэрхүү номнуудаас дэлхий шүүгдэх болно.
- 27 Мөн шударга байх, та нарт миний өгөх шүүлтийн дагуу та нар энэ хүмүүсийн шүүгчид байх болно хэмээн та нарыг мэдээсэй хэмээнэ. Тиймийн тул, та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ? Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу.

And this is the word which he hath given unto the children of men. And for this cause he fulfilled the words which he hath given, and he lieth not, but fulfilleth all his words.

And no unclean thing can enter into his kingdom; therefore nothing entereth into his rest save it be those who have washed their garments in my blood, because of their faith, and the repentance of all their sins, and their faithfulness unto the end.

Now this is the commandment: Repent, all ye ends of the earth, and come unto me and be baptized in my name, that ye may be sanctified by the reception of the Holy Ghost, that ye may stand spotless before me at the last day.

Verily, verily, I say unto you, this is my gospel; and ye know the things that ye must do in my church; for the works which ye have seen me do that shall ye also do; for that which ye have seen me do even that shall ye do;

Therefore, if ye do these things blessed are ye, for ye shall be lifted up at the last day.

Write the things which ye have seen and heard, save it be those which are forbidden.

Write the works of this people, which shall be, even as hath been written, of that which hath been.

For behold, out of the books which have been written, and which shall be written, shall this people be judged, for by them shall their works be known unto men.

And behold, all things are written by the Father; therefore out of the books which shall be written shall the world be judged.

And know ye that ye shall be judges of this people, according to the judgment which I shall give unto you, which shall be just. Therefore, what manner of men ought ye to be? Verily I say unto you, even as I am.

28 Мөн эдүгээ би Эцэгтээ очно. Мөн үнэнээр би та нарт хэлье, та нар Эцэгээс миний нэрээр гуйсан юу боловч, тэр зүйл та нарт өгөгдөх болно.

29 Тиймийн тул гуй, тэгвэл та нар хүлээн авна, тогш, тэгвэл энэ нь та нарт нээгдэх болно; учир нь гуйсан тэр нь хүлээн авна; мөн тогших түүнд, энэ нь нээгдэх болно.

30 Мөн эдүгээ, болгоогтун, та нарын, мөн түүнчлэн энэ үеийнхний учир баясал минь агуу байна, бүр дүүртлээ; тийм ээ, мөн түүнчлэн бүх ариун тэнгэр элчүүд, та нарын мөн энэ үеийнхний учир бүр Эцэг ч баясана; учир нь тэдний хэн нь ч төөрөлдөөгүй бөлгөө.

31 Болгоогтун, та нарыг ойлгоосой хэмээнэ би; учир нь тэд гэж энэ үеийн эдүгээ амьд байгаа тэднийг би хэлсэн билээ; мөн тэдний хэн нь ч алдагдсангүй; мөн тэдний улмаас би баяслын дүүрнийг амсах бөлгөө.

32 Гэвч болгоогтун, энэ үеэс дөрөв дэх үеийнхний учир би харамсана, учир нь тэд бүр мөхлийн хүү лугаа адил боолчлолд түүгээр удирдагдан одох бөлгөө; учир нь мөнгөний төлөө мөн алтны төлөө, мөн цагаан эрвээхэйд идэгдэх мөн хулгайч нар эвдэж ороод мөн хулгайлж болох зүйлийн төлөө тэд намайг худалдах болно. Мөн тэр өдөр бүх ажлуудыг нь өөрсдийнх нь тэргүүнүүд дээр эргүүлсэн би тэдэнд зочлох болно.

33 Мөнхүү улиран тохиох дор эдгээр үгсээ Есүс дуусгаад тэрээр шавь нартаа хэлэв: давчуу хаалгаар орогтун та нар; учир юун гэвэл аминд удирдах хаалга нь давчуу, мөн зам нь нарийн, мөн үүнийг олох нь цөөн бөлгөө; харин үхэлд удирдах хаалга өргөн, мөн зам нь дардан, мөн түүгээр замнах нь олон болой, ямар ч хүмүүн ажиллаж үл чадах тэр шөнийг ирэх хүртэл бөлгөө.

And now I go unto the Father. And verily I say unto you, whatsoever things ye shall ask the Father in my name shall be given unto you.

Therefore, ask, and ye shall receive; knock, and it shall be opened unto you; for he that asketh, receiveth; and unto him that knocketh, it shall be opened.

And now, behold, my joy is great, even unto fulness, because of you, and also this generation; yea, and even the Father rejoiceth, and also all the holy angels, because of you and this generation; for none of them are lost.

Behold, I would that ye should understand; for I mean them who are now alive of this generation; and none of them are lost; and in them I have fulness of joy.

But behold, it sorroweth me because of the fourth generation from this generation, for they are led away captive by him even as was the son of perdition; for they will sell me for silver and for gold, and for that which moth doth corrupt and which thieves can break through and steal. And in that day will I visit them, even in turning their works upon their own heads.

And it came to pass that when Jesus had ended these sayings he said unto his disciples: Enter ye in at the strait gate; for strait is the gate, and narrow is the way that leads to life, and few there be that find it; but wide is the gate, and broad the way which leads to death, and many there be that travel therein, until the night cometh, wherein no man can work.

### 3 Нифай 28

- 1 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг хэлээд, тэрээр шавь нартаа, нэг нэгээр нь ярьж, тэдэнд хэлсэн нь: намайг Эцэгтээ очсоны дараа, та нар надаас юу хүсэх вэ
- 2 Мөн тэд бүгд ярьж, гурваас бусад нь хэлэв: Бид хүний насыг насалсны дараа, бид таны хаант улсад танд хурдан очиж болно хэмээн биднийг таны дуудсан тохинуулал маань төгсөж болохыг бид хүсч байна.
- 3 Мөн тэрээр тэдэнд хэлэв: Та нар энэ зүйлийг надаас хүссэн учраас адислагдсан болой та нар; тиймийн тул, та нар даланхоёр настай болсныхоо дараа хаант улсад минь надад ирэх болно; мөн надтай хамт та нар амар амгаланг олох болно.
- 4 Мөн тэрээр тэдэнд ярьсныхаа дараа, тэрээр сайхь гурвын зүг эргэж, мөн тэдэнд хэлэв: Намайг Эцэгтээ очоод, та нарын төлөө намайг юу хийхийг та нар хүсч байна
- 5 Мөн тэд зүрх сэтгэлдээ харамсав, учир нь хүссэн зүйлээ түүнд ярьж тэд зүрхэлсэнгүй.
- 6 Мөн тэрээр тэдэнд хэлэв: Болгоогтун, би та нарын бодлуудыг мэднэ, мөн намайг иудейчүүдээр өргөгдөхөөс өмнө, миний тохинуулалд надтай хамт байсан, миний хайрт Иохан надаас хүссэн тэр зүйлийг та нар хүсч буй.
- 7 Тиймийн тул, та нар илүүтэй адислагдсан болой, учир нь та нар хэзээ ч үхлийг амсахгүй; харин бүр намайг тэнгэрийн хүчтэйгээр алдар суундаа ирэх үед, Эцэгийн тааллын дагуу бүх зүйл гүйцэлдэх хүртэл та нар хүмүүний үрсэд Эцэгийн бүх үйлүүдийг болгоохоор амьдрах болно.
- 8 Мөн та нар үхлийн шаналлыг хэзээ ч үзэхгүй; харин намайг алдар суундаа ирэх үед та нар нүд ирмэхийн зуур зуурдын байдлаас үхэшгүй байдалд өөрчлөгдөх болно; мөн тэгээд та нар миний Эцэгийн хаант улсад адислагдах болно.

### 3 Nephi 28

And it came to pass when Jesus had said these words, he spake unto his disciples, one by one, saying unto them: What is it that ye desire of me, after that I am gone to the Father?

And they all spake, save it were three, saying: We desire that after we have lived unto the age of man, that our ministry, wherein thou hast called us, may have an end, that we may speedily come unto thee in thy kingdom.

And he said unto them: Blessed are ye because ye desired this thing of me; therefore, after that ye are seventy and two years old ye shall come unto me in my kingdom; and with me ye shall find rest.

And when he had spoken unto them, he turned himself unto the three, and said unto them: What will ye that I should do unto you, when I am gone unto the Father?

And they sorrowed in their hearts, for they durst not speak unto him the thing which they desired.

And he said unto them: Behold, I know your thoughts, and ye have desired the thing which John, my beloved, who was with me in my ministry, before that I was lifted up by the Jews, desired of me.

Therefore, more blessed are ye, for ye shall never taste of death; but ye shall live to behold all the doings of the Father unto the children of men, even until all things shall be fulfilled according to the will of the Father, when I shall come in my glory with the powers of heaven.

And ye shall never endure the pains of death; but when I shall come in my glory ye shall be changed in the twinkling of an eye from mortality to immortality; and then shall ye be blessed in the kingdom of my Father.

- 9 Мөн тэрчлэн, бие махбодид орших үед та нарт зовуурь үгүй байх болно, бас дэлхийн нүглүүдийн төлөө бус аваас харамсал ч үгүй байх бөлгөө; мөн та нарын надаас хүссэн тэр зүйлийн учир би энэ бүгдийг хийх болно, учир нь дэлхий оршин тогтнож байхад, хүмүүний бодгалийг надад авчирч болох болоосой хэмээн та нар хүссэн билээ.
- 10 Мөн энэ шалтгааны улмаас та нарт баяслын бүрэн дүүрэн нь байх болно; мөн та нар миний Эцэгийн хаант улсад суух болно; тийм ээ, баясал тань дүүрэн байх болно, бүр Эцэг надад баяслын бүрэн дүүрнийг өгсөн лугаа адил бөлгөө; мөн та нар бүр миний адил байх болно, мөн би бол бүр Эцэгийн адил, мөн Эцэг бид хоёр нэг билээ;
- 11 Мөн Ариун Сүнс Эцэгийн болон миний тухай гэрчилдэг; мөн Эцэг хүмүүний үрсэд миний учир, Ариун Сүнс өгдөг.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Есүс эдгээр үгийг яриад, тэрээр үлдэх гурваас бусдад нэг бүрчлэн хуруугаараа хүрч, мөн тэгээд тэрбээр одов.
- 13 Мөн болгоогтун, тэнгэр нээгдэж, мөн тэд тэнгэрт шүүрэгдэж, мөн өгүүлшгүй зүйлийг харж бас сонсов.
- 14 Мөн тэдний хэлэх нь тэдэнд хориглогдов; бас тэд үзсэн мөн сонссон зүйлүүдээ ярьж чадах хүч тэдэнд өгөгдсөнгүй;
- 15 Мөн тэд бие махбодид эсвээс бие махбодийн гадна байсан эсэхээ тэд хэлж чадсангүй; учир нь энэ бол тэдэнд өөрсдийнх нь хувиралт мэт санагдаж, тэд Бурханы зүйлийг болгоож чадахын тулд тэд махан бодийн энэ биеэсээ үхэшгүй байдалд өөрчлөгдөв.
- 16 Гэвч улиран тохиох дор тэд газрын гадаргуу дээр дахин тохинуулав; гэсэн хэдий ч тэнгэрт тэдэнд өгөгдсөн тэр зарлигийн учир, тэд сонссон мөн үзсэн зүйлүүдийнхээ тухайд тохинуулсангүй.
- 17 Мөн эдүгээ, тэдний хувиргалтын өдрөөс хойш, тэд зуурдын эсвээс үхэшгүй байсан эсэхийг би мэдэх нь үгүй;

And again, ye shall not have pain while ye shall dwell in the flesh, neither sorrow save it be for the sins of the world; and all this will I do because of the thing which ye have desired of me, for ye have desired that ye might bring the souls of men unto me, while the world shall stand.

And for this cause ye shall have fulness of joy; and ye shall sit down in the kingdom of my Father; yea, your joy shall be full, even as the Father hath given me fulness of joy; and ye shall be even as I am, and I am even as the Father; and the Father and I are one;

And the Holy Ghost beareth record of the Father and me; and the Father giveth the Holy Ghost unto the children of men, because of me.

And it came to pass that when Jesus had spoken these words, he touched every one of them with his finger save it were the three who were to tarry, and then he departed.

And behold, the heavens were opened, and they were caught up into heaven, and saw and heard unspeakable things.

And it was forbidden them that they should utter; neither was it given unto them power that they could utter the things which they saw and heard;

And whether they were in the body or out of the body, they could not tell; for it did seem unto them like a transfiguration of them, that they were changed from this body of flesh into an immortal state, that they could behold the things of God.

But it came to pass that they did again minister upon the face of the earth; nevertheless they did not minister of the things which they had heard and seen, because of the commandment which was given them in heaven.

And now, whether they were mortal or immortal, from the day of their transfiguration, I know not;

18 Харин өгөгдсөн тэрхүү цэдгийн дагуу, би энэ зэргийг мэднэ—тэд уг нутгийн гадаргуу дээр урагш явж, мөн бүх хүмүүст тохинуулан, номлолд нь итгэсэн болгоныг сүмд нэгтгэв; тэдэнд баптисм хүртээж, мөн баптисм хүртсэн болгон нь Ариун Сүнс хүлээн авсан болой.

19 Мөн тэд сүмд харьяалагдаагүй тэднээр шоронд хаягдав. Мөн шоронгууд ч, тэдгээр нь хоёр хуваагдан цуурсаны учир тэднийг барьж хүч хүрсэнгүй.

20 Мөн тэд газар дор хаягдав; гэвч тэд Бурханы үгээр уг газрыг цохиж, үүний хэрээр түүний хүчээр тэд газрын гүнээс чөлөөлөгдөв; мөн тиймийн тул тэднийг барьж байх тийм нүхнүүдийг тэд ухаж чадсангүй.

21 Мөн тэд зууханд гурвантаа хаягдаж тэгээд гэмтэл авсангүй.

22 Мөн тэд зэрлэг араатны үүрэнд хоёр удаа хаягдав; мөн болгоогтун тэд хөхүүл хүүхэд хургатай лугаа адил мэт тэр араатнуудтай тоглож, мөн гэмтэл авсангүй.

23 Мөнхүү улиран тохиох дор тэд тийн Нифайн бүх хүмүүсийн дунд явж, мөн Христийн сайн мэдээг уг нутгийн гадаргуу дээрх бүх хүмүүст номлов; мөн тэд Их Эзэнд хөрвүүлэгдэж, мөн Христийн сүмд нэгтгэгдэв, мөн тийн тэр үеийн хүмүүс, Есүсийн үгийн дагуу адислагдав.

24 Мөн эдүгээ, би, Мормон, эдгээр зүйлийн талаарх яриагаа хэсэг зуур төгсгөл болгоё.

25 Болгоогтун, би үхлийг хэзээ ч амсахгүй тэдний нэрсийг бичих гэж байв, гэвч Их Эзэн хориглосон бөлгөө; тиймийн тул би тэдгээрийг бичихгүй, учир нь тэд дэлхийгээс нуугдсан билээ.

26 Гэвч болгоогтун, би тэднийг харсан, мөн тэд надад тохинуулсан бөлгөө.

27 Мөн болгоогтун тэд харийнханы дунд байх болно, мөн харийнхан тэднийг мэдэх нь үгүй.

28 Тэд түүнчлэн Иудейн дунд ч байх болно, мөн иудейчүүд тэднийг мэдэх нь үгүй.

But this much I know, according to the record which hath been given—they did go forth upon the face of the land, and did minister unto all the people, uniting as many to the church as would believe in their preaching; baptizing them, and as many as were baptized did receive the Holy Ghost.

And they were cast into prison by them who did not belong to the church. And the prisons could not hold them, for they were rent in twain.

And they were cast down into the earth; but they did smite the earth with the word of God, insomuch that by his power they were delivered out of the depths of the earth; and therefore they could not dig pits sufficient to hold them.

And thrice they were cast into a furnace and received no harm.

And twice were they cast into a den of wild beasts; and behold they did play with the beasts as a child with a suckling lamb, and received no harm.

And it came to pass that thus they did go forth among all the people of Nephi, and did preach the gospel of Christ unto all people upon the face of the land; and they were converted unto the Lord, and were united unto the church of Christ, and thus the people of that generation were blessed, according to the word of Jesus.

And now I, Mormon, make an end of speaking concerning these things for a time.

Behold, I was about to write the names of those who were never to taste of death, but the Lord forbade; therefore I write them not, for they are hid from the world.

But behold, I have seen them, and they have ministered unto me.

And behold they will be among the Gentiles, and the Gentiles shall know them not.

They will also be among the Jews, and the Jews shall know them not.

- 29 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн өөрийн мэргэн ухаанд таарна хэмээн үзэхэд, тэд Израилын бүх тараагдсан овгуудад, мөн бүх үндэстэн, ястан, хэлтэн мөн хүмүүст тохинуулах болно, мөн тэдний хүсэл гүйцэлдэж болохын тулд, мөн түүнчлэн тэдэнд буй Бурханы итгүүлэх хүчний учир тэднээс олон бодгалийг Есүст авчрах болно.
- 30 Мөн тэд Бурханы тэнгэр элчүүдийн адил, мөн хэрэв тэд Есүсийн нэрээр Эцэгт залбирах аваас тэд өөрсдийн хувьд сайн гэгдэх ямар ч хүмүүнд өөрсдийгөө үзүүлж чадна.
- 31 Тиймийн тул, бүх хүмүүс гарцаагүй Христийн шүүлтийн суудлын өмнө зогсох ёстой агуу хийгээд ирэх өдрөөс өмнө тэднээр агуу хийгээд гайхамшигт үйлүүд хийгдэх болно;
- 32 Тийм ээ тэр шүүлтийн өдрийн өмнө тэднээр хийгдэх агуу хийгээд гайхамшигт ажил бүр харийнханы дунд ч байх болно.
- 33 Мөн хэрэв Христийн бүх гайхамшигт ажлуудын шастирыг өгөх тэр бүх судрууд та нарт байсан аваас, та нар Христийн үгсийн дагуу, эдгээр зүйл гарцаагүй ирэх ёстойг мэдэх сэн билээ.
- 34 Мөн Есүсийн үгсийг сонсохгүй түүнд, мөн түүнчлэн түүний сонгож мөн тэдний дунд илгээсэн тэдэнд халаг болог; учир нь Есүсийн үгсийг мөн түүний илгээсэн тэдний үгсийг хүлээн аваагүй хэн ч түүнийг хүлээн авахгүй; мөн тиймийн тул тэрээр эцсийн өдөр тэднийг хүлээн авахгүй байх болно;
- 35 Мөн тэдний хувьд хэрэв тэд төрөөгүй байсан бол илүү дээр байх сан. Учир нь хүмүүний хөл дор дэвслэгдсэн тэрхүү, гомдсон Бурханы шударга ёсноос, түүгээр аврал ирж болох тэрнээс та нар зайлсхийж чадна хэмээн та нар бодно уу
- 36 Мөн эдүгээ болгоогтун, Их Эзэний сонгосон тэдний, тийм ээ, бүр тэнгэрт шүүрэгдсэн тэр гурвын талаар, тэд зуурдын байдлаас үхэшгүй байдалд цэвэршүүлэгдсэн эсэхийг би мэдсэнгүй хэмээн би ярьсан учир—
- 37 Гэвч болгоогтун, бичсэнийхээ дараа, би Их Эзэнээс лавлаж, мөн тэрээр надад тэдний биесэд өөрчлөлт хийгдсэн байх ёстой, эсвээс тэд үхлийг амсах ёстой хэмээн надад илэрхийлсэн бөлгөө;

And it shall come to pass, when the Lord seeth fit in his wisdom that they shall minister unto all the scattered tribes of Israel, and unto all nations, kindreds, tongues and people, and shall bring out of them unto Jesus many souls, that their desire may be fulfilled, and also because of the convincing power of God which is in them.

And they are as the angels of God, and if they shall pray unto the Father in the name of Jesus they can show themselves unto whatsoever man it seemeth them good.

Therefore, great and marvelous works shall be wrought by them, before the great and coming day when all people must surely stand before the judgment-seat of Christ;

Yea even among the Gentiles shall there be a great and marvelous work wrought by them, before that judgment day.

And if ye had all the scriptures which give an account of all the marvelous works of Christ, ye would, according to the words of Christ, know that these things must surely come.

And wo be unto him that will not hearken unto the words of Jesus, and also to them whom he hath chosen and sent among them; for whoso receiveth not the words of Jesus and the words of those whom he hath sent receiveth not him; and therefore he will not receive them at the last day;

And it would be better for them if they had not been born. For do ye suppose that ye can get rid of the justice of an offended God, who hath been trampled under feet of men, that thereby salvation might come?

And now behold, as I spake concerning those whom the Lord hath chosen, yea, even three who were caught up into the heavens, that I knew not whether they were cleansed from mortality to immortality—

But behold, since I wrote, I have inquired of the Lord, and he hath made it manifest unto me that there must needs be a change wrought upon their bodies, or else it needs be that they must taste of death;



- 38 Тиймийн тул, тэд үхлийг амсаж болохгүйн тулд, тэд дэлхийн нүглүүдийн улмаас бус аваас өвчнийг бас харамслыг амсахгүйн тулд тэдний биесэд өөрчлөлт хийгдсэн ажээ.
- 39 Эдүгээ энэ өөрчлөлт нь эцсийн өдөр тохиох түүнтэй тэнцэх нь үгүй; харин тэдний дээр өөрчлөлт хийгдсэн, үүний хэрээр тэднийг давах хүчийг Сатан үл эзэмшсэнээс, тэрээр тэднийг уруу татаж чадахгүй; мөн тэд бие махбодиоо ариусгагдсанаас ариун болж, мөн газар дэлхийн хүч тэднийг барьж чадахгүй болжээ.
- 40 Мөн энэ байдалд тэд Христийн шүүлтийн өдөр хүртэл үлдэх бөлгөө; мөн тэр өдөр тэд илүү агуу өөрчлөлтийг хүлээн авна, мөн Эцэгийн хаант улсад хойшид гарахгүйгээр хүлээн авагдана, тэгээд тэнгэрт Бурхантай мөнхөд орших болно.

Therefore, that they might not taste of death there was a change wrought upon their bodies, that they might not suffer pain nor sorrow save it were for the sins of the world.

Now this change was not equal to that which shall take place at the last day; but there was a change wrought upon them, insomuch that Satan could have no power over them, that he could not tempt them; and they were sanctified in the flesh, that they were holy, and that the powers of the earth could not hold them.

And in this state they were to remain until the judgment day of Christ; and at that day they were to receive a greater change, and to be received into the kingdom of the Father to go no more out, but to dwell with God eternally in the heavens.

### 3 Нифай 29

- 1 Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ Их Эзэн өөрийн мэргэн ухаанд таарна хэмээн үзэхэд, эдгээр үгс түүний үгийн дагуу харийнханд ирэх болно, тэгээд өөрсдийн өвлөсөн нутаг дахь тэдний сэргээлтийн талаар Израилын хүүхдүүдтэй Эцэгийн хийсэн гэрээ аль хэдийн гүйцэлдэж эхэлснийг та нар мэднэ.
- 2 Мөн ариун бошиглогчдоор яригдсан, Их Эзэний үгс бүгд гүйцэлдэх болно гэдгийг та нар мэдэж болно; мөн Их Эзэн Израилын хүүхдүүдэд ирэхээ хойшлуулна хэмээн та нар хэлэх хэрэггүй.
- 3 Мөн яригдсан үгс нь хоосон хэмээн та нар зүрх сэтгэлдээ төсөөлөх хэрэггүй, учир нь болгоогтун, Их Эзэн өөрийнх нь болох Израилын угсааны хүмүүстэй хийсэн гэрээгээ санах болно.
- 4 Мөн эдгээр үгс та нарын дунд ирэхийг харах үедээ, тэгээд та нар цаашид Их Эзэний үйлүүдийг жигшин эсэргүүцэх хэрэггүй, учир нь түүний шударга ёсны илд баруун гарт нь байна; мөн болгоогтун, тэр өдөр, хэрэв та нар түүний үйлүүдийг жигшин эсэргүүцэх аваас тэрбээр энэ нь та нарыг удалгүй эзэрхийлэх болгоно.
- 5 Их Эзэний үйлүүдийг жигшин эсэргүүцэх түүнд халаг; тийм ээ, Христийг болон түүний ажлуудыг үгүйсгэх түүнд халаг!
- 6 Тийм ээ, Их Эзэний илчлэлтүүдийг үгүйсгэх, мөн Их Эзэн илчлэлтээр, эсвээс бошиглолоор, эсвээс бэлгээр, эсвээс хэлээр, эсвээс эдгээлтээр, эсвээс Ариун Сүнсний хүчээр ажиллахаа больсон хэмээн хэлэх түүнд халаг!
- 7 Тийм ээ, баялгийг хураахын тулд, Есүс Христээр ямар ч гайхамшиг хийгдэх аргагүй хэмээн тэр өдөр хэлэх түүнд халаг; учир нь үүнийг хийх тэр нь Христийн үгийн дагуу, нигүүлсэл үгүй байсан сайхь мөхлийн хүүтэй адил болох болно!
- 8 Тийм ээ, иудейчүүдийг, бас Израилын угсааны үлдэгдлийн хэнийг ч та нар цаашид шүд зуун хараах, бас жигшин эсэргүүцэх ч, бас тохуурхах ч хэрэггүй; учир нь болгоогтун, Их Эзэн тэдэнтэй хийсэн гэрээгээ санадаг, мөн тэрбээр тангарагласныхаа дагуу тэдэнд үйлдэх болно.

### 3 Nephi 29

And now behold, I say unto you that when the Lord shall see fit, in his wisdom, that these sayings shall come unto the Gentiles according to his word, then ye may know that the covenant which the Father hath made with the children of Israel, concerning their restoration to the lands of their inheritance, is already beginning to be fulfilled.

And ye may know that the words of the Lord, which have been spoken by the holy prophets, shall all be fulfilled; and ye need not say that the Lord delays his coming unto the children of Israel.

And ye need not imagine in your hearts that the words which have been spoken are vain, for behold, the Lord will remember his covenant which he hath made unto his people of the house of Israel.

And when ye shall see these sayings coming forth among you, then ye need not any longer spurn at the doings of the Lord, for the sword of his justice is in his right hand; and behold, at that day, if ye shall spurn at his doings he will cause that it shall soon overtake you.

Wo unto him that spurneth at the doings of the Lord; yea, wo unto him that shall deny the Christ and his works!

Yea, wo unto him that shall deny the revelations of the Lord, and that shall say the Lord no longer worketh by revelation, or by prophecy, or by gifts, or by tongues, or by healings, or by the power of the Holy Ghost!

Yea, and wo unto him that shall say at that day, to get gain, that there can be no miracle wrought by Jesus Christ; for he that doeth this shall become like unto the son of perdition, for whom there was no mercy, according to the word of Christ!

Yea, and ye need not any longer hiss, nor spurn, nor make game of the Jews, nor any of the remnant of the house of Israel; for behold, the Lord remembereth his covenant unto them, and he will do unto them according to that which he hath sworn.

9 Тиймийн тул гэрбээр Израилын угсаатай хийсэн гэрээний биелэлтэд хүргэн шүүлтийг гүйцэтгэхгүй байж болохын тулд, Их Эзэний баруун мутрыг зүүнээр нь өөрчилж чадна хэмээн та нар бодох хэрэггүй.

Therefore ye need not suppose that ye can turn the right hand of the Lord unto the left, that he may not execute judgment unto the fulfilling of the covenant which he hath made unto the house of Israel.

### 3 Нифай 30

- 1 Анхаарагтун, Ай харийнхан та нар, та нарын талаар ярихыг надад зарлиг болгосон амьд Бурханы Хүү, Есүс Христийн үгсийг сонсогтун, учир нь, болгоогтун тэрбээр бичихийг надад зарлиг болгов, өгүүлсэн нь:
- 2 Бүх харийнхан та нар, ёс бус замуудаасаа эргэгтүн; та нар нүглүүдийнхээ ангижралыг хүлээн авч, мөн Ариун Сүнсээр дүүргэгдэж болохын тулд, та нар Израилын угсааных болох миний хүмүүстэй хамт тоологдож болохын тулд мөн хилэнцэт үйлүүдээсээ, худал хэлэхээ мөн заль мэхүүдээ, мөн садар самуун үйлүүдээ, мөн нууц жигшүүрт хэргүүдээ, мөн хиймэл шүтээн шүтэхээ, мөн аллагуудаа, мөн санваараар мэргэших явдлаа, мөн атаа жөтөөгөө, мөн хэрүүл маргаанаа, мөн өөрсдийн бүх ёс бус явдлуудаа мөн жигшүүрт хэргүүдээ наманчлагтун, мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүрт.

### 3 Nephi 30

Hearken, O ye Gentiles, and hear the words of Jesus Christ, the Son of the living God, which he hath commanded me that I should speak concerning you, for, behold he commandeth me that I should write, saying:

Turn, all ye Gentiles, from your wicked ways; and repent of your evil doings, of your lyings and deceivings, and of your whoredoms, and of your secret abominations, and your idolatries, and of your murders, and your priestcrafts, and your envyings, and your strifes, and from all your wickedness and abominations, and come unto me, and be baptized in my name, that ye may receive a remission of your sins, and be filled with the Holy Ghost, that ye may be numbered with my people who are of the house of Israel.

# ДӨРӨВДҮГЭЭР НИФАЙ НИФАЙН НОМ ЕСҮС ХРИСТИЙН ШАВЬ НАРЫН НЭГ БОЛОХ НИФАЙН ХҮҮ БОЛОЙ.

*Түүний цэдгийн дагуух, Нифайн хүмүүсийн шастир оршвой.*

- 1 МӨНХҮҮ улиран тохиох дор гучин дөрөв дэх он, мөн гучин тав дахь он улиран одож, мөн болгоогтун Есүсийн шавь нар Христийн сүмийг эргэн тойрны бүх нутагт байгуулав. Мөн тэдэн дээр ирсэн, мөн нүглүүдээсээ үнэнээр наманчилсан болгон нь, Есүсийн нэрээр баптисм хүртэв; мөн тэд түүнчлэн Ариун Сүнс хүлээн авав.
- 2 Мөнхүү улиран тохиох дор гучин зургаа дахь онд, нутгийн бүх гадаргуу дээр, уг хүмүүс, нифайчууд болон леменчүүд аль аль нь, бүгдээр Их Эзэнд хөрвүүлэгдэв, мөн тэдний дунд зөрчилдөөн мөн арцалдаан байсангүй, мөн хүмүүн бүр нэг нэгэнтэйгээ шударгаар харьцаж байлаа.
- 3 Мөн тэд өөрсдийн дунд бүх зүйлийг нийтээр эзэмшиж байв; тиймийн тул баян ба ядуу, боол ба чөлөөт гэж байсангүй, харин тэд бүгдээр эрх чөлөөтэй, мөн тэнгэрлэг бэлгээс хүртэгсэд болгогдов.
- 4 Мөнхүү улиран тохиох дор гучин долоо дахь он түүнчлэн улиран одож, мөн уг нутагт амар амгалан үргэлжилсээр байв.
- 5 Мөн Есүсийн шавь нараар үйлдэгдсэн агуу хийгээд гайхамшигтай үйлүүд байв, үүний хэрээр тэд өвчтэйг эдгээж, мөн үхсэнийг босгож, мөн доголонг алхдаг, мөн хараагүйг хараатай, мөн дүлийг сонсдог болгож байв; мөн бүх төрлийн гайхамшгуудыг тэд хүмүүний үрсийн дунд үйлдсэн буюу; мөн Есүсийн нэрээр бус аваас тэд юугаар ч гайхамшгуудыг үйлдсэн нь үгүй.

## Fourth Nephi

### The Book of Nephi

#### Who Is the Son of Nephi—One of the Disciples of Jesus Christ

*An account of the people of Nephi, according to his record.*

And it came to pass that the thirty and fourth year passed away, and also the thirty and fifth, and behold the disciples of Jesus had formed a church of Christ in all the lands round about. And as many as did come unto them, and did truly repent of their sins, were baptized in the name of Jesus; and they did also receive the Holy Ghost.

And it came to pass in the thirty and sixth year, the people were all converted unto the Lord, upon all the face of the land, both Nephites and Lamanites, and there were no contentions and disputations among them, and every man did deal justly one with another.

And they had all things common among them; therefore there were not rich and poor, bond and free, but they were all made free, and partakers of the heavenly gift.

And it came to pass that the thirty and seventh year passed away also, and there still continued to be peace in the land.

And there were great and marvelous works wrought by the disciples of Jesus, insomuch that they did heal the sick, and raise the dead, and cause the lame to walk, and the blind to receive their sight, and the deaf to hear; and all manner of miracles did they work among the children of men; and in nothing did they work miracles save it were in the name of Jesus.

6 Мөн тийн гучин найм дахь, мөн түүнчлэн гучин ес дэх, мөн дөчин нэг дэх, мөн дөчин хоёр дахь он улиран одов, тийм ээ, бүр дөчин есөн он улирч одох хүртэл, мөн түүнчлэн тавин нэг дэх, мөн тавин хоёр дахь; тийм ээ, мөн бүр тавин есөн он хүртэл улирч одсон ажгуу.

7 Мөн Их Эзэн тэднийг уг нутагт үлэмж дэгжүүлэв; тийм ээ, үүний хэрээр тэд хотууд шатаагдсан тэнд хотуудыг дахин барьсан буюу.

8 Тийм ээ, бүр агуу хот Зарахемлаг тэд дахин баригдах болгов.

9 Гэвч живүүлэгдсэн олон хот байв, мөн тэдгээрийн оронд ус байх болжээ; тиймийн тул эдгээр хотууд дахин шинэчлэгдэх аргагүй байв.

10 Мөн эдүгээ, болгоогтун, улиран тохиох дор Нифайн хүмүүс хүчирхэгжиж, мөн үлэмж түргэнээр өнөржиж, мөн тэд үлэмж хонгорхон мөн бахдам сайхан хүмүүс болов.

11 Мөн тэд гэрлэж, мөн гэрлэхээр өгөгдөв, мөн Их Эзэн тэдэнд өгсөн олон тооны амлалтуудын дагуу адислагдав.

12 Мөн тэд Мосегийн хуулийн гүйцэтгэл хийгээд ёслолуудын дагуу цаашид алхсангүй; гэвч тэд өөрсдийн Их Эзэн мөн өөрсдийн Бурханаас хүлээн авсан зарлигуудын дагуу алхаж, залбирч мөн Их Эзэний үгийг сонсохоор хамтдаа ойр ойрхон цугларахаа, мөн мацаг барилт мөн залбирлыг үргэлжлүүлсээр байв.

13 Мөнхүү улиран тохиох дор бүх нутагт, бүх хүмүүсийн дунд зөрчилдөөн огт үгүй байв; харин Есүсийн шавь нарын дунд үйлдэгдсэн сүр хүчит гайхамшгууд байлаа.

14 Мөнхүү улиран тохиох дор далан нэгдүгээр он улирч одов, мөн түүнчлэн далан хоёрдугаар он, тийм ээ, мөн эцэст нь далан есдүгээр оныг хүртэл улирч одов; тийм ээ, бүр зуун жил улирч одсон байв, мөн Есүсийн сонгосон шавь нар нь, үлдэх гурваас бусад нь бүгд Бурханы диваажинд одсон байв; мөн тэдний оронд өөр шавь нар томилогдов; мөн түүнчлэн уг үеийнхнээс олон нь талийгаач болжээ.

And thus did the thirty and eighth year pass away, and also the thirty and ninth, and forty and first, and the forty and second, yea, even until forty and nine years had passed away, and also the fifty and first, and the fifty and second; yea, and even until fifty and nine years had passed away.

And the Lord did prosper them exceedingly in the land; yea, insomuch that they did build cities again where there had been cities burned.

Yea, even that great city Zarahemla did they cause to be built again.

But there were many cities which had been sunk, and waters came up in the stead thereof; therefore these cities could not be renewed.

And now, behold, it came to pass that the people of Nephi did wax strong, and did multiply exceedingly fast, and became an exceedingly fair and delightsome people.

And they were married, and given in marriage, and were blessed according to the multitude of the promises which the Lord had made unto them.

And they did not walk any more after the performances and ordinances of the law of Moses; but they did walk after the commandments which they had received from their Lord and their God, continuing in fasting and prayer, and in meeting together oft both to pray and to hear the word of the Lord.

And it came to pass that there was no contention among all the people, in all the land; but there were mighty miracles wrought among the disciples of Jesus.

And it came to pass that the seventy and first year passed away, and also the seventy and second year, yea, and in fine, till the seventy and ninth year had passed away; yea, even an hundred years had passed away, and the disciples of Jesus, whom he had chosen, had all gone to the paradise of God, save it were the three who should tarry; and there were other disciples ordained in their stead; and also many of that generation had passed away.

15 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн зүрх сэтгэлд орших Бурханы хайрын учир, уг нутагт зөрчилдөөн огт байсангүй.

16 Мөн атаа жөтөө, бас хэрүүл маргаан, бас үймээн, садар самуун ч, худал хэлэх нь ч, аллага ч, ямар ч төрлийн шунал тачаал байсангүй; мөн Бурханы мутраар бүтээгдсэн бүх хүмүүсийн дунд илүү аз жаргалтай хүмүүс байх аргагүй нь гарцаагүй юм.

17 Дээрэмчид ч, алуурчингууд ч, бас леменчүүд ч, бүр ямар ч -чууд байсангүй, харин тэд, Христийн хүүхдүүд, мөн Бурханы хаант улсын өв залгамжлагчид гэгдэн нэг болсон байв.

18 Мөн хичнээн их адислагдсан билээ тэд! Учир нь Их Эзэн тэдний бүх үйлд тэднийг адисалсан болой; тийм ээ, бүр зуун арван жил улирч одох хүртэл тэд адислагдан мөн дэгжээгдсэн буюу; мөн Христээс хойш эхний үе улирч одсон байв, мөн бүх нутагт зөрчилдөөн огт байсангүй.

19 Мөнхүү улиран тохиох дор Нифай, энэхүү сүүлчийн цэдгийг хөтөлсөн тэрээр, (мөн тэрбээр үүнийг Нифайн ялтсууд дээр хөтөлсөн буюу) нас нөгчив, мөн түүний хүү Амос түүний оронд үүнийг хөтлөв; мөн тэрбээр үүнийг түүнчлэн Нифайн ялтсууд дээр хөтөлсөн ажээ.

20 Мөн тэрбээр үүнийг наян дөрвөн жил хөтөлж, мөн уг нутагт, сүмээс дайжиж мөн леменчүүдийн нэрийг өөрсөд дээрээ авсан хүмүүсийн багахан хэсгээс бусдаар, амар амгалан байсаар байв; тиймийн тул уг нутагт дахин леменчүүд гэж бий болж эхлэв.

21 Мөнхүү улиран тохиох дор түүнчлэн Амос нас нөгчиж, (мөн энэ нь Христийн ирснээс хойш зуун ерөндөрвөн жил байсан буюу) мөн түүний хүү Амос түүний оронд уг цэдгийг хөтлөв; мөн тэрбээр үүнийг Нифайн ялтсууд дээр хөтлөв; мөн энэ нь бас, энэ ном болох Нифайн номонд бичигдсэн бөлгөө.

22 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун жил улирч одсон байв; мөн цөөхөн хэдээс бусдаар хоёр дахь үеийнхэн бүгд талийгаач болсон байв.

23 Мөн эдүгээ би, Мормон, уг хүмүүс өнөржсөн, үүний хэрээр уг нутгийн бүхэл гадаргуу дээгүүр тархсан, мөн Христ дэх дэгжлийнхээ улмаас тэд үлэмж баян болсныг та нар мэдээсэй хэмээнэ.

And it came to pass that there was no contention in the land, because of the love of God which did dwell in the hearts of the people.

And there were no envyings, nor strifes, nor tumults, nor whoredoms, nor lyings, nor murders, nor any manner of lasciviousness; and surely there could not be a happier people among all the people who had been created by the hand of God.

There were no robbers, nor murderers, neither were there Lamanites, nor any manner of -ites; but they were in one, the children of Christ, and heirs to the kingdom of God.

And how blessed were they! For the Lord did bless them in all their doings; yea, even they were blessed and prospered until an hundred and ten years had passed away; and the first generation from Christ had passed away, and there was no contention in all the land.

And it came to pass that Nephi, he that kept this last record, (and he kept it upon the plates of Nephi) died, and his son Amos kept it in his stead; and he kept it upon the plates of Nephi also.

And he kept it eighty and four years, and there was still peace in the land, save it were a small part of the people who had revolted from the church and taken upon them the name of Lamanites; therefore there began to be Lamanites again in the land.

And it came to pass that Amos died also, (and it was an hundred and ninety and four years from the coming of Christ) and his son Amos kept the record in his stead; and he also kept it upon the plates of Nephi; and it was also written in the book of Nephi, which is this book.

And it came to pass that two hundred years had passed away; and the second generation had all passed away save it were a few.

And now I, Mormon, would that ye should know that the people had multiplied, insomuch that they were spread upon all the face of the land, and that they had become exceedingly rich, because of their prosperity in Christ.

- 24 Мөн эдүгээ, энэхүү хоёр зуун нэг дэх онд тэдний дунд, үнэтэй өмсгөл өмсөх, мөн бүх төрлийн тансаг сувд, мөн ертөнцийн тансаг эдлэлүүдээс өмсөх гэх мэтээр бардамналд хөөргөгдсөн тэд байж эхлэв.
- 25 Мөн тэр цагаас хойш тэд өөрсдийн эд агуурс хийгээд өмч хөрөнгөө дундаа нийтээр эзэмшихээ болив.
- 26 Мөн тэд зиндаагаар хуваагдаж эхлэв; мөн тэд ашиг олохын тулд өөрсдөдөө сүм барьж эхлэв, мөн Христийн үнэн сүмийг үгүйсгэж эхлэв.
- 27 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун арван жил улирч одсон үед уг нутагт олон сүм байв; тийм ээ, Христийг мэднэ хэмээн тунхагладаг авч түүний сайн мэдээний ихээхэн хэсгийг үгүйсгэж, үүний хэрээр тэд бүх төрлийн ёс бусын үйлийг хүлээж авч, мөн зохисгүй байдлынх нь улмаас түүнийг хүртэх нь хориглогдсон нэгэнд, ариун нандин болох түүнийг хүртээж байсан олон сүм байлаа.
- 28 Мөн энэ сүм алдсын улмаас, мөн тэдний зүрх сэтгэлийг эзэмдсэн Сатаны хүчний улмаас үлэмж дэвжив.
- 29 Мөн түүнчлэн, Христийг үгүйсгэсэн өөр нэгэн сүм байв; мөн тэд Христийн үнэн сүмийг, тэдний даруу байдал хийгээд Христэд итгэх тэдний итгэлийнх нь улмаас хавчиж байв; мөн тэдний дунд үйлдэгдсэн олон гайхамшигийн улмаас тэд тэднийг үзэн яддаг байв.
- 30 Тиймийн тул тэдэнтэй үлдсэн Есүсийн шавь нарын дээр хүч болон эрх мэдлийг тэд хэрэгжүүлэн, мөн тэднийг шоронд хаяв; гэвч тэдэнд байсан Бурханы үгийн хүч чадлаар, шоронгууд хоёр хуваагдан цуурч, мөн тэдний дунд хүчит гайхамшгуудыг тэд үйлдэн явцгаасан бөлгөө.
- 31 Гэсэн хэдий ч, мөн эдгээр бүх гайхамшиг байсан хэдий ч, хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж, мөн өөрийнх нь үгийн дагуу, Иерусалим дахь иудейчүүд Есүсийг хөнөөхөөр эрэлхийлсний адилаар, тэднийг алахаар эрэлхийлж байв.
- 32 Мөн тэд тэднийг галт зууханд хаяж, мөн тэд гэмтэлгүйгээр гарч иржээ.

And now, in this two hundred and first year there began to be among them those who were lifted up in pride, such as the wearing of costly apparel, and all manner of fine pearls, and of the fine things of the world.

And from that time forth they did have their goods and their substance no more common among them.

And they began to be divided into classes; and they began to build up churches unto themselves to get gain, and began to deny the true church of Christ.

And it came to pass that when two hundred and ten years had passed away there were many churches in the land; yea, there were many churches which professed to know the Christ, and yet they did deny the more parts of his gospel, insomuch that they did receive all manner of wickedness, and did administer that which was sacred unto him to whom it had been forbidden because of unworthiness.

And this church did multiply exceedingly because of iniquity, and because of the power of Satan who did get hold upon their hearts.

And again, there was another church which denied the Christ; and they did persecute the true church of Christ, because of their humility and their belief in Christ; and they did despise them because of the many miracles which were wrought among them.

Therefore they did exercise power and authority over the disciples of Jesus who did tarry with them, and they did cast them into prison; but by the power of the word of God, which was in them, the prisons were rent in twain, and they went forth doing mighty miracles among them.

Nevertheless, and notwithstanding all these miracles, the people did harden their hearts, and did seek to kill them, even as the Jews at Jerusalem sought to kill Jesus, according to his word.

And they did cast them into furnaces of fire, and they came forth receiving no harm.



33 Мөн тэд түүнчлэн тэднийг зэрлэг араатны үүрэнд хаясан ч, мөн тэд хургатай тоглож буй хүүхэд лугаа адил зэрлэг араатнуудтай тоглов; мөн тэд гэмтэл авалгүй, тэдний дундаас гарч ирэв.

34 Гэсэн хэдий ч, хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулав, учир нь олон санваартан мөн хуурамч бошиглогчдоор олон сүм баригдахад, мөн бүх төрлийн алдсыг үйлдэхэд тэд удирдагдав. Мөн тэд Есүсийн хүмүүсийг цохив; гэвч Есүсийн хүмүүс хариуд нь буцааж цохьсонгүй. Мөн ийн тэд жилээс жилд, бүр хоёр зуун гучин жил улирч одох хүртэл, итгэлгүйдээ мөн ёс бусын үйлдээ бууран доройтов.

35 Мөн эдүгээ улиран тохиох дор тэр онд, тийм ээ, хоёр зуун гучин нэг дэх онд, хүмүүсийн дунд нэгэн агуу хагарал болов.

36 Мөнхүү улиран тохиох дор тэрхүү онд нифайчууд хэмээн нэрлэгдсэн хүмүүс гарч ирэв, мөн тэд Христэд үнэн итгэгчид байв; мөн тэдний дунд леменчүүдээр нэрлэгдсэнээр—иаковчууд, иосефчүүд, зорамчууд болох тэд байв;

37 Тиймийн тул Христэд үнэн итгэгсэд, мөн Христийг үнэн бишрэн шүтэгсэд, (үлдэх болсон Есүсийн гурван шавь тэдний дунд байсан буюу) нь нифайчууд, мөн иаковчууд, мөн иосефчүүд, мөн зорамчууд хэмээн нэрлэгддэг байсан бөлгөө.

38 Мөнхүү улиран тохиох дор сайн мэдээг эсэргүүцсэн тэд леменчүүд, мөн лемүелчүүд, мөн ишмәилчүүд хэмээн нэрлэгддэг байв; мөн тэд итгэлгүйдээ бууран доройтсон бус, харин тэд Христийн сайн мэдээний эсрэг санаатайгаар эсэргүүцэж байв; мөн бүр тэдний эцэг өвгөд нь эхлэлээс бууран доройтсоны адилаар, тэд итгэх ёсгүй хэмээн хүүхдүүддээ заадаг байв.

39 Мөн энэ нь бүр эхлэлд байсны адилаар, тэдний эцэг өвгөдийн ёс бус хийгээд жигшүүрт үйлийн улмаас байсан буюу. Мөн, эхлэлээс леменчүүд Нифайн хүүхдүүдийг үзэн ядахыг заалгасны адилаар, тэд Бурханы хүүхдүүдийг үзэн ядахыг заалгасан ажгуу.

40 Мөнхүү улиран тохиох дор хоёр зуун дөчин дөрвөн жил улирч одсон байв, мөн хүмүүсийн хэрэг явдал тийн байв. Мөн хүмүүсийн илүү ёс бус хэсэг нь хүчирхэгжиж, мөн Бурханы хүмүүсээс үлэмж илүү олон тоотой болов.

And they also cast them into dens of wild beasts, and they did play with the wild beasts even as a child with a lamb; and they did come forth from among them, receiving no harm.

Nevertheless, the people did harden their hearts, for they were led by many priests and false prophets to build up many churches, and to do all manner of iniquity. And they did smite upon the people of Jesus; but the people of Jesus did not smite again. And thus they did dwindle in unbelief and wickedness, from year to year, even until two hundred and thirty years had passed away.

And now it came to pass in this year, yea, in the two hundred and thirty and first year, there was a great division among the people.

And it came to pass that in this year there arose a people who were called the Nephites, and they were true believers in Christ; and among them there were those who were called by the Lamanites—Jacobites, and Josephites, and Zoramites;

Therefore the true believers in Christ, and the true worshipers of Christ, (among whom were the three disciples of Jesus who should tarry) were called Nephites, and Jacobites, and Josephites, and Zoramites.

And it came to pass that they who rejected the gospel were called Lamanites, and Lemuelites, and Ishmaelites; and they did not dwindle in unbelief, but they did wilfully rebel against the gospel of Christ; and they did teach their children that they should not believe, even as their fathers, from the beginning, did dwindle.

And it was because of the wickedness and abomination of their fathers, even as it was in the beginning. And they were taught to hate the children of God, even as the Lamanites were taught to hate the children of Nephi from the beginning.

And it came to pass that two hundred and forty and four years had passed away, and thus were the affairs of the people. And the more wicked part of the people did wax strong, and became exceedingly more numerous than were the people of God.

41 Мөн тэд өөрсдөдөө сүмүүдийг барьсаар, мөн тэдгээрийг бүх төрлийн үнэт зүйлээр чимэглэсээр байв. Мөн тийн хоёр зуун тавин жил, мөн түүнчлэн хоёр зуун жаран жил улиран одов.

42 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн ёс бус хэсэг нь Гадантоны нууц тангараг хийгээд хуйвалдааныг дахин байгуулж эхлэв.

43 Мөн түүнчлэн Нифайн хүмүүс гэж нэрлэгддэг асан тэдгээр хүмүүс, үлэмж баялгийнхаа улмаас, зүрх сэтгэлдээ бардамнаж эхлэв, мөн өөрсдийн ахан дүүс леменчүүдийн адилаар, хоосон сагсуурах болов.

44 Мөн энэ цагаас шавь нар дэлхийн нүглүүдийн төлөө гашуудаж эхлэв.

45 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жил улирч одоход, Нифайн хүмүүс болоод леменчүүдийн аль аль нэг нь нөгөөгийнхээ адилаар үлэмж ёс бус болцгоосон байв.

46 Мөнхүү улиран тохиох дор Гадантоны дээрэмчид нутгийн бүх гадаргуу дээгүүр тархав; мөн Есүсийн шавь нараас өөр зөв шударга нэгэн байсангүй. Мөн алт мөн мөнгийг тэд элбэг дэлбэгээр хадгалан агуулж, мөн бүх төрлийн арилжаанд наймаалцаж байлаа.

47 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун таван жил улирч одсоны дараа, (мөн уг хүмүүс ёсон бусад үлдсэн хэвээр байв) Амос нас нөгчив; мөн түүний дүү, Аммарон, түүний оронд цэдгийг хөтлөв.

48 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун хорин жил улирч одсоны дараа, Аммарон, Ариун Сүнсээр албадуулагдан, нандин цэдгүүдийг—тийм ээ, бүр ариун нандин болох, үеэс үед гардуулагдан ирсэн, тэрхүү бүх ариун нандин цэдгийг—бүр Христийн ирэлтээс гурван зуун хорь дахь оныг хүртэлхийг нуув.

49 Мөн тэдгээр нь Их Эзэний бошиглол мөн амлалтуудын дагуу, Иаковын угсааны үлдэгдэлд дахин ирж болохын тул, тэрбээр тэдгээрийг Их Эзэний төлөө нуусан бөлгөө. Мөн Аммароны цэдгийн төгсгөлийн байв.

And they did still continue to build up churches unto themselves, and adorn them with all manner of precious things. And thus did two hundred and fifty years pass away, and also two hundred and sixty years.

And it came to pass that the wicked part of the people began again to build up the secret oaths and combinations of Gadianton.

And also the people who were called the people of Nephi began to be proud in their hearts, because of their exceeding riches, and become vain like unto their brethren, the Lamanites.

And from this time the disciples began to sorrow for the sins of the world.

And it came to pass that when three hundred years had passed away, both the people of Nephi and the Lamanites had become exceedingly wicked one like unto another.

And it came to pass that the robbers of Gadianton did spread over all the face of the land; and there were none that were righteous save it were the disciples of Jesus. And gold and silver did they lay up in store in abundance, and did traffic in all manner of traffic.

And it came to pass that after three hundred and five years had passed away, (and the people did still remain in wickedness) Amos died; and his brother, Ammaron, did keep the record in his stead.

And it came to pass that when three hundred and twenty years had passed away, Ammaron, being constrained by the Holy Ghost, did hide up the records which were sacred—yea, even all the sacred records which had been handed down from generation to generation, which were sacred—even until the three hundred and twentieth year from the coming of Christ.

And he did hide them up unto the Lord, that they might come again unto the remnant of the house of Jacob, according to the prophecies and the promises of the Lord. And thus is the end of the record of Ammaron.

# МОРМОНЫ НОМ

## Мормон 1

- 1 Мөн эдүгээ би, Мормон, өөрийн үзэж бас сонссон зүйлүүдийн цэдгийг бүтээе, мөн үүнийг Мормоны Ном хэмээн нэрлэе.
- 2 Мөн Аммарон Их Эзэний төлөө цэдгүүдийг нуусан тэр үеийн орчим, тэрбээр надад ирж, (би арав орчим настай, мөн өөрийн хүмүүсийн эрдэм мэдлэгийн дагуу би ямар нэг хэмжээгээр суралцаж эхэлсэн байв) мөн Аммарон надад хэлсэн нь: Чи бол хэрсүү хүүхэд, мөн ажиглан ойлгохдоо түргэн болохыг би ухамсарлаж байна;
- 3 Тиймийн тул, чи хорин дөрөв орчим настай болох үедээ, энэ хүмүүсийн талаар ажигласан зүйлүүдээ чамайг санаасай хэмээн би хүснэ; мөн тэр насандаа чи Антамын нутаг тийш, Шим хэмээн нэрлэгдэх толгойг хүртэл явагтун; мөн энэ хүмүүсийн талаарх бүх ариун нандин сийлбэрүүдийг Их Эзэний төлөө би тэнд хадгалсан буй.
- 4 Мөн болгоогтун, чи Нифайн ялтсуудыг өөртөө авах болно, мөн үлдсэнийг нь тэдгээрийн байгаа тэр газарт нь үлдээх болно; мөн чи Нифайн ялтсууд дээр энэ хүмүүсийн талаар өөрийн ажигласан бүх зүйлүүдийг сийлбэрлэх болно.
- 5 Мөн би, Мормон, Нифайн удам болохоор, (мөн миний эцгийн нэр нь Мормон байсан буюу) Аммарон надад зарлиг болгосон зүйлүүдийг би санах.
- 6 Мөнхүү улиран тохиох дор би, арван нэгэн настай байхдаа, өмнө зүгийн нутаг тийш, бүр Зарахемлагийн нутагт эцгээрээ хүргэгдэв.
- 7 Уг нутгийн бүх гадаргуу нь барилгуудаар бүрхэгдсэн байж, мөн хүмүүс нь бараг л тэнгисийн элс мэт олон тоотой байв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор энэ онд, нифайчууд болон иаковчууд, мөн иосефчүүд, мөн зорамчуудаас бүрдсэн нифайчууд дайнд оров; мөн энэ дайн нь нифайчууд, мөн леменчүүд болон лемүелчүүд түүнчлэн ишмэлчүүдийн хооронд байсан бөлгөө.

# The Book of Mormon

## Mormon 1

- And now I, Mormon, make a record of the things which I have both seen and heard, and call it the Book of Mormon.
- And about the time that Ammaron hid up the records unto the Lord, he came unto me, (I being about ten years of age, and I began to be learned somewhat after the manner of the learning of my people) and Ammaron said unto me: I perceive that thou art a sober child, and art quick to observe;
- Therefore, when ye are about twenty and four years old I would that ye should remember the things that ye have observed concerning this people; and when ye are of that age go to the land Antum, unto a hill which shall be called Shim; and there have I deposited unto the Lord all the sacred engravings concerning this people.
- And behold, ye shall take the plates of Nephi unto yourself, and the remainder shall ye leave in the place where they are; and ye shall engrave on the plates of Nephi all the things that ye have observed concerning this people.
- And I, Mormon, being a descendant of Nephi, (and my father's name was Mormon) I remembered the things which Ammaron commanded me.
- And it came to pass that I, being eleven years old, was carried by my father into the land southward, even to the land of Zarahemla.
- The whole face of the land had become covered with buildings, and the people were as numerous almost, as it were the sand of the sea.
- And it came to pass in this year there began to be a war between the Nephites, who consisted of the Nephites and the Jacobites and the Josephites and the Zoramites; and this war was between the Nephites, and the Lamanites and the Lemuelites and the Ishmaelites.

9 Эдүгээ леменчүүд болон лемүелчүүд мөн иш-  
мэйлчүүд нь леменчүүд хэмээн нэрлэгдэж, мөн хоёр  
тал нь нифайчууд болон леменчүүд байв.

10 Мөнхүү улиран тохиох дор тэдний дунд  
Зарахемлагийн хил дээр, Сидоны усны дэргэд, дайн  
эхлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд агуу тоо-  
ны, бүр гучин мянгаас давах тооны эрчүүдийг нэгт-  
гэн цуглуулсан байв. Мөнхүү улиран тохиох дор тэр-  
хүү жилд нифайчууд, леменчүүдийг цохин мөн тэд-  
нээс олныг нь хөнөөсөн хэд хэдэн тулалдаанд оров.

12 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд төлөвлөс-  
нөө орхиж, мөн уг нутагт амар амгалан тогтов; мөн  
тэрхүү амар амгалан нь дөрвөн жил орчмын туршид  
байв, тиймээс ямар ч цус урссангүй.

13 Гэвч бүх нутгийн гадаргуу дээр ёс бус үйл газар  
авч, үүний хэрээр Их Эзэн өөрийн хайрт шавь нарыг  
холдуулан авч, мөн гайхамшигийн болоод эдгээх үй-  
лүүд хүмүүсийн алдсын улмаас байхаа болив.

14 Мөн тэдний ёс бус үйл мөн үл итгэх байдлын ул-  
маас, Их Эзэнээс ямар ч бэлэг байсангүй, мөн Ариун  
Сүнс хэний ч дээр ирсэнгүй.

15 Мөн би, арван таван настай байхдаа мөн ямартай  
ч хэрсүү ухаантай байсны учир, тиймийн тул би Их  
Эзэнээр зочлогдон, мөн Есүсийн сайн сайхныг ам-  
талж мөн мэдэв.

16 Мөн би энэ хүмүүст номлохыг хичээв, гэвч миний  
ам хаагдаж, мөн би тэдэнд номлох нь хориглогдов;  
учир нь болгоогтун тэд Бурханаа санаатайгаар эсэр-  
гүүцэж байв; мөн тэдний алдсын улмаас хайрт шавь  
нар нь уг нутгаас холдуулан авагдсан бөлгөө.

17 Гэвч би тэдний дунд үлдэв, харин тэдний зүрх сэт-  
гэл хатуугийн улмаас, би тэдэнд номлох нь хориг-  
логдсон буюу; мөн тэдний зүрх сэтгэлийн хатуугийн  
улмаас уг нутаг тэдний улмаас зүхэгдсэн бөлгөө.

18 Мөн леменчүүдийн дунд байсан Гадиантоны дээ-  
рэмчид уг нутагт бужигналдан, үүний хэрээр үүний  
оршин суугчид эд баялгаа газарт нууж эхлэв; мөн Их  
Эзэн уг нутгийг зүхсэний улмаас, тэдгээр нь гулгамт-  
гай болж, тиймээс тэд дахин тэдгээрийг барьж, бас  
эзэмшин үлдээж чадсангүй.

Now the Lamanites and the Lemuelites and the  
Ishmaelites were called Lamanites, and the two parties  
were Nephites and Lamanites.

And it came to pass that the war began to be among  
them in the borders of Zarahemla, by the waters of  
Sidon.

And it came to pass that the Nephites had gathered  
together a great number of men, even to exceed the  
number of thirty thousand. And it came to pass that  
they did have in this same year a number of battles, in  
which the Nephites did beat the Lamanites and did slay  
many of them.

And it came to pass that the Lamanites withdrew  
their design, and there was peace settled in the land; and  
peace did remain for the space of about four years, that  
there was no bloodshed.

But wickedness did prevail upon the face of the  
whole land, insomuch that the Lord did take away his  
beloved disciples, and the work of miracles and of heal-  
ing did cease because of the iniquity of the people.

And there were no gifts from the Lord, and the Holy  
Ghost did not come upon any, because of their wicked-  
ness and unbelief.

And I, being fifteen years of age and being somewhat  
of a sober mind, therefore I was visited of the Lord, and  
tasted and knew of the goodness of Jesus.

And I did endeavor to preach unto this people, but  
my mouth was shut, and I was forbidden that I should  
preach unto them; for behold they had wilfully rebelled  
against their God; and the beloved disciples were taken  
away out of the land, because of their iniquity.

But I did remain among them, but I was forbidden to  
preach unto them, because of the hardness of their  
hearts; and because of the hardness of their hearts the  
land was cursed for their sake.

And these Gadianton robbers, who were among the  
Lamanites, did infest the land, insomuch that the in-  
habitants thereof began to hide up their treasures in the  
earth; and they became slippery, because the Lord had  
cursed the land, that they could not hold them, nor re-  
tain them again.

19 Мөнхүү улиран тохиох дор ид шидүүд, мөн шулмын арга, мөн илбэ байв; мөн бүх нутгийн гадаргуу дээр, бүр Абинадай, мөн түүнчлэн лемен үндэстэн Самуелын бүх үгсийн биелэл болон уг хилэнцэт нэгний хүч чадал үйлдэгдэж байв.

And it came to pass that there were sorceries, and witchcrafts, and magics; and the power of the evil one was wrought upon all the face of the land, even unto the fulfilling of all the words of Abinadi, and also Samuel the Lamanite.

## Мормон 2

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэр нэгэн жилд нифайчууд болон леменчүүдийн хооронд дахин дайн эхлэв. Мөн би залуу байсан хэдий ч, биеэр том байв; тиймийн тул Нифайн хүмүүс намайг өөрсдийн удирдагч, өөрөөр хэлбэл их цэргийнхээ удирдагчаар томилов.
- 2 Тиймийн тул улиран тохиох дор би арван зургаа дахь насандаа нифайчуудын их цэргийн тэргүүнд, леменчүүдийн эсрэг явсан билээ; тиймийн тул гурван зуун хорин зургаан жил улиран одсон байв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун хорин долоо дахь онд леменчүүд бидний дээр үлэмж агуу хүчээр ирж, үүний хэрээр тэд миний их цэргийг сүрдүүлэв; тиймийн тул тэд тулалдсангүй, мөн тэд умард нутгуудыг чиглэн ухарч эхлэв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор бид Анголын хотод ирээд, мөн бид хотыг эзэмшилдээ авч, мөн леменчүүдээс өөрсдийгөө хамгаалахаар бэлтгэл хийв. Мөнхүү улиран тохиох дор бид өөрсдийн хүчээр хотыг бэхлэв; бидний бүх бэхлэлт байсан хэдий ч леменчүүд бидний дээр ирж мөн биднийг уг хотоос зайлуулав.
- 5 Мөн тэд түүнчлэн биднийг Давидын нутгаас зайлуулав.
- 6 Мөн бид жагсан алхаж мөн, тэнгисийн эргийн дэргэд өрнөд хилд байх Иошуагийн нутагт ирэв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор бид тэднийг нэгтгэн хамтатгаж болохын тулд, өөрсдийн хүмүүсийг аль болох хурднаар цуглуулав.
- 8 Гэвч болгоогтун, уг нутаг дээрэмчдээр мөн леменчүүдээр дүүрсэн байв; мөн миний хүмүүсийн дээгүүр нүүрлэх агуу устгал байсан хэдий ч, тэд хилэнцэт үйлүүдээ наманчилсангүй; тиймийн тул нифайчуудын тал мөн түүнчлэн леменчүүдийн талын аль алинд нь, нутгийн бүх гадаргуу дээгүүр, цус мөн хядаан тархав; мөн энэ нь уг нутгийн бүх гадаргуу дээгүүр бүхнийг хамарсан үймээн байв.

## Mormon 2

And it came to pass in that same year there began to be a war again between the Nephites and the Lamanites. And notwithstanding I being young, was large in stature; therefore the people of Nephi appointed me that I should be their leader, or the leader of their armies.

Therefore it came to pass that in my sixteenth year I did go forth at the head of an army of the Nephites, against the Lamanites; therefore three hundred and twenty and six years had passed away.

And it came to pass that in the three hundred and twenty and seventh year the Lamanites did come upon us with exceedingly great power, insomuch that they did frighten my armies; therefore they would not fight, and they began to retreat towards the north countries.

And it came to pass that we did come to the city of Angola, and we did take possession of the city, and make preparations to defend ourselves against the Lamanites. And it came to pass that we did fortify the city with our might; but notwithstanding all our fortifications the Lamanites did come upon us and did drive us out of the city.

And they did also drive us forth out of the land of David.

And we marched forth and came to the land of Joshua, which was in the borders west by the seashore.

And it came to pass that we did gather in our people as fast as it were possible, that we might get them together in one body.

But behold, the land was filled with robbers and with Lamanites; and notwithstanding the great destruction which hung over my people, they did not repent of their evil doings; therefore there was blood and carnage spread throughout all the face of the land, both on the part of the Nephites and also on the part of the Lamanites; and it was one complete revolution throughout all the face of the land.

- 9 Мөн эдүгээ, леменчүүд хаантай байлаа, мөн түүний нэр Аарон байв; мөн тэрбээр бидний эсрэг дөчин дөрвөн мянган цэрэг эрстэйгээр ирэв. Мөн болгоогтун, дөчин хоёр мянгатайгаа би түүнийг сөрөн зогсов. Мөнхүү улиран тохиох дор би түүнийг өөрийн их цэрэгтэйгээ дийлснээс тэрбээр миний өмнө зугтав. Мөн болгоогтун, энэ бүхэн тохиож, мөн гурван зуун гучин жил улирч одсон байлаа.
- 10 Мөнхүү улиран тохиох дор бошиглогч Самуелын бошиглосончлон нифайчууд алдсаа наманчилж эхлэв, мөн уйлж эхлэв; учир нь болгоогтун, уг нутагт байсан хулгайч нар, мөн дээрэмчид, мөн алуурчид, мөн илбийн ид шид, мөн шулмын аргын учир хэн ч өөрийн болох юуг ч хадгалж чадахгүй байлаа.
- 11 Тийн бүх нутагт, мөн ялангуяа Нифайн хүмүүсийн дунд эдгээр зүйлүүдийн улмаас гашуудал мөн гаслан байж эхлэв.
- 12 Мөнхүү улиран тохиох дор би, Мормон, Их Эзэний өмнөх тэдний гашуудал мөн тэдний гаслан мөн тэдний харууслыг үзээд, дотроо зүрх сэтгэлдээ баясч эхлэв, Их Эзэний нигүүлсэл хийгээд тэсвэрийг мэдсэний учир, тиймийн тул тэд дахин зөв шударга хүмүүс болохын тулд тэрбээр тэдэнд нигүүлсэнгүй хандах болов уу хэмээн бодов.
- 13 Гэвч болгоогтун миний энэ баяр хөөр хий хоосон байв, учир нь тэдний харуусал Бурханы сайн сайхны улмаас наманчлалд хүргэсэнгүй; харин, нүгэлдээ аз жаргалыг хүртэхийг нь Их Эзэн тэдэнд байнга эс зөвшөөрдгийн улмаас энэ нь яллагдагсдын харуусал байсан буюу.
- 14 Мөн тэд харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр Есүст ирсэнгүй, харин тэд Бурханыг зүхэж, мөн үхэхийг хүсч байв. Гэсэн хэдий ч тэд амьдралынхаа төлөө илдээр тэмцэх болно.
- 15 Мөнхүү улиран тохиох дор миний харуусал дахин надад ирж, мөн ач ивээлийн өдөр тэдний хувьд, биеийн мөн сүнсний хувьд ч өнгөрсөн болохыг би харсан юм; учир нь тэдний мянга мянгыг Бурханаа илтээр эсэргүүцээд унагаагдахыг, мөн уг нутгийн гадаргуу дээр өтөг бууц мэт овоологдохыг харсан буюу би. Мөн тийн гурван зуун дөчин дөрвөн жил улирч одсон байв.

And now, the Lamanites had a king, and his name was Aaron; and he came against us with an army of forty and four thousand. And behold, I withstood him with forty and two thousand. And it came to pass that I beat him with my army that he fled before me. And behold, all this was done, and three hundred and thirty years had passed away.

And it came to pass that the Nephites began to repent of their iniquity, and began to cry even as had been prophesied by Samuel the prophet; for behold no man could keep that which was his own, for the thieves, and the robbers, and the murderers, and the magic art, and the witchcraft which was in the land.

Thus there began to be a mourning and a lamentation in all the land because of these things, and more especially among the people of Nephi.

And it came to pass that when I, Mormon, saw their lamentation and their mourning and their sorrow before the Lord, my heart did begin to rejoice within me, knowing the mercies and the long-suffering of the Lord, therefore supposing that he would be merciful unto them that they would again become a righteous people.

But behold this my joy was vain, for their sorrowing was not unto repentance, because of the goodness of God; but it was rather the sorrowing of the damned, because the Lord would not always suffer them to take happiness in sin.

And they did not come unto Jesus with broken hearts and contrite spirits, but they did curse God, and wish to die. Nevertheless they would struggle with the sword for their lives.

And it came to pass that my sorrow did return unto me again, and I saw that the day of grace was passed with them, both temporally and spiritually; for I saw thousands of them hewn down in open rebellion against their God, and heaped up as dung upon the face of the land. And thus three hundred and forty and four years had passed away.

- 16 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун дөчин тав дахь онд нифайчууд леменчүүдийн өмнө зугтаж эхлэв; мөн тэдний ухралганд тэднийг зогсоох боломжтой болохын өмнө, тэд бүр Жашоны нутагт ирэх хүртлээ мөрдөгдсөн ажгуу.
- 17 Мөн эдүгээ, Жашоны хот нь Аммарон цэдгүүдийг, тэдгээр нь устгагдахгүй байж болохын тулд, Их Эзэний төлөө хадгалсан тэр нутгийн ойр байв. Мөн болгоогтун би Аммароны үгийн дагуу явж, мөн Нифайн ялтсуудыг авч, мөн Аммароны үгсийн дагуу цэдгийг үйлдэв.
- 18 Мөн Нифайн ялтсууд дээр би бүх ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн бүрэн шастирыг бичсэн болой; гэвч эдгээр ялтсууд дээр би тэдний ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн бүрэн шастирыг үйлдэхээс татгалзав, учир нь болгоогтун, би хүмүүний замналыг болгоох болсон тэр цагаас ёс бус хийгээд жигшүүрт хэргүүдийн үргэлжийн дүр зураг нүдний минь өмнө байсан буюу.
- 19 Мөн тэдний ёс бусын улмаас би халаглаж байна; учир нь миний бүх өдрүүдэд, тэдний ёс бусын улмаас зүрх сэтгэл минь харууслаар дүүрсээр ирсэн юм; гэсэн хэдий ч, эцсийн өдөр өргөгдөх болно гэдгээ би мэднэ.
- 20 Мөнхүү улиран тохиох дор энэ жилд Нифайн хүмүүс дахин мөрдөгдөж мөн хөөгдөв. Мөнхүү улиран тохиох дор бид Шем хэмээн нэрлэгдэх умард зүгийн нутагт ирэх хүртлээ бид хөөгдсөн буюу.
- 21 Мөнхүү улиран тохиох дор бид Шем хотыг бэхлэв, мөн бид тэднийг устгагдахаас аварч магадын тул, бид аль болох олноор боломжийн хэрээр өөрсдийн хүмүүсийг цуглуулсан болой.
- 22 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун дөчин зургаа дахь онд тэд бидний дээр дахин ирж эхлэв.
- 23 Мөнхүү улиран тохиох дор би өөрийн хүмүүстэй ярьж, мөн тэд леменчүүдийн өмнө өөрсдийн эхнэр, мөн өөрсдийн хүүхдүүд, мөн өөрсдийн байшин, мөн гэр орныхоо төлөө зоригтойгоор зогсохыг агуу эрч хүчээр тэдэнд уриалав.
- 24 Мөн миний үгс тэднийг ямартай ч зоригжуулан босгож, үүний хэрээр тэд леменчүүдийн өмнө зугтсангүй, харин тэдний эсрэг зоригтойгоор зогсов.

And it came to pass that in the three hundred and forty and fifth year the Nephites did begin to flee before the Lamanites; and they were pursued until they came even to the land of Jashon, before it was possible to stop them in their retreat.

And now, the city of Jashon was near the land where Ammaron had deposited the records unto the Lord, that they might not be destroyed. And behold I had gone according to the word of Ammaron, and taken the plates of Nephi, and did make a record according to the words of Ammaron.

And upon the plates of Nephi I did make a full account of all the wickedness and abominations; but upon these plates I did forbear to make a full account of their wickedness and abominations, for behold, a continual scene of wickedness and abominations has been before mine eyes ever since I have been sufficient to behold the ways of man.

And wo is me because of their wickedness; for my heart has been filled with sorrow because of their wickedness, all my days; nevertheless, I know that I shall be lifted up at the last day.

And it came to pass that in this year the people of Nephi again were hunted and driven. And it came to pass that we were driven forth until we had come northward to the land which was called Shem.

And it came to pass that we did fortify the city of Shem, and we did gather in our people as much as it were possible, that perhaps we might save them from destruction.

And it came to pass in the three hundred and forty and sixth year they began to come upon us again.

And it came to pass that I did speak unto my people, and did urge them with great energy, that they would stand boldly before the Lamanites and fight for their wives, and their children, and their houses, and their homes.

And my words did arouse them somewhat to vigor, insomuch that they did not flee from before the Lamanites, but did stand with boldness against them.



25 Мөнхүү улиран тохиох дор гучин мянгатай их цэрэгтэйгээр бид тавин мянгатай их цэргийн эсрэг тэмцсэн юм. Мөнхүү улиран тохиох дор тэд бидний өмнө зугтах болсон тийм тууштайгаар бид тэдний өмнө зогсов.

26 Мөнхүү улиран тохиох дор тэднийг зугтахад бид тэднийг их цэрэгтэйгээ мөрдөн хөөж, мөн тэдэнтэй дахин тулав, мөн тэднийг бут цохьсон буюу; гэсэн хэдий ч Их Эзэний хүч бидэнтэй хамт байсангүй; тийм ээ, Их Эзэний Сүнс бидэнтэй эс үлдсэнээс бид өөрсдөдөө л найдах болов; тиймийн тул бид ахан дүүсийнхээ адил сул дорой болсон байв.

27 Мөн миний хүмүүсийн, тэдний ёс бус хийгээд тэдний жигшүүрт хэргүүдийн улмаас, энэ агуу гай гамшгийн улмаас, зүрх сэтгэл минь харуусав. Гэвч болгоогтун, бид леменчүүдийн мөн Гадиантоны дээрэмчдийн эсрэг, бид дахин өвийн нутгуудаа эзэмшилдээ авах хүртлээ явсан бөлгөө.

28 Мөн гурван зуун дөчин ес дэх он улирч одов. Мөн гурван зуун тавь дахь онд бид леменчүүд хийгээд Гадиантоны дээрэмчидтэй хэлцэл байгуулж, түүгээр өвийн нутгуудаа бид хуваалгав.

29 Мөн леменчүүд, тийм ээ, бүр өмнөд нутагт хөтлөх нарийн гарц хүртлэх умард зүгийн нутгийг бидэнд өгсөн бөлгөө. Мөн бид өмнө зүгийн бүх нутгийг леменчүүдэд өгөв.

And it came to pass that we did contend with an army of thirty thousand against an army of fifty thousand. And it came to pass that we did stand before them with such firmness that they did flee from before us.

And it came to pass that when they had fled we did pursue them with our armies, and did meet them again, and did beat them; nevertheless the strength of the Lord was not with us; yea, we were left to ourselves, that the Spirit of the Lord did not abide in us; therefore we had become weak like unto our brethren.

And my heart did sorrow because of this the great calamity of my people, because of their wickedness and their abominations. But behold, we did go forth against the Lamanites and the robbers of Gadianton, until we had again taken possession of the lands of our inheritance.

And the three hundred and forty and ninth year had passed away. And in the three hundred and fiftieth year we made a treaty with the Lamanites and the robbers of Gadianton, in which we did get the lands of our inheritance divided.

And the Lamanites did give unto us the land northward, yea, even to the narrow passage which led into the land southward. And we did give unto the Lamanites all the land southward.

## Мормон 3

- 1 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд арван жил улирч одох хүртэл дахин тулалдахаар ирсэнгүй. Мөн болгоогтун, би өөрийн хүмүүс, нифайчуудыг, нутгаа мөн зэр зэвсгээ тулааны цагт бэлтгэхээр хөдөлмөрлүүлэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэлэв: Энэ хүмүүст ийн тунхагла—Наманчлагтун та нар, мөн надад ирэгтүн, мөн баптисм хүртэгтүн та нар, мөн миний сүмийг дахин байгуулагтун, мөн та нар хэлтрүүлэгдэх болно.
- 3 Мөн би энэ хүмүүст тунхаглав, гэвч энэ нь хий хоосон болов; мөн тэднийг хэлтрүүлсэн, мөн тэдэнд наманчлалын боломж олгосон нь Их Эзэн байсныг тэд ухаарсангүй. Мөн болгоогтун тэд Их Эзэн Бурханыхаа эсрэг зүрх сэтгэлээ хатууруулжээ.
- 4 Мөнхүү улиран тохиох дор Христийн ирэлтээс хойш, бүхэлдээ гурван зуун жаран жил болж, энэ арав дахь жил улирч одсоны дараа, тэд дахин бидний эсрэг тулалдахаар бэлтгэж байгааг леменчүүдийн хаан надад мэдэгдсэн захидал илгээв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор би Эзгүйрэлийн нутагт, хил дээр орших хотод, өмнө зүгийн нутаг тийш хөтөлсөн нарийн гармын ойр өөрийн хүмүүсийг цугларах болгов.
- 6 Мөн бид леменчүүдийн их цэргийг зогсоож болохын тул, тэд бидний аль ч нутгийг эзэмшилдээ авахгүй байж болохын тулд, бид тэнд өөрсдийн их цэргийг байрлуулав; тиймийн тул бид бүх хүчээрээ тэдний эсрэг бэхлэлт босгов.
- 7 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран нэгдэх онд леменчүүд бидний эсрэг тулалдахаар уруудан Эзгүйрэлийн хотод ирэв; мөнхүү улиран тохиох дор тэр жилд бид тэднийг ялж, үүний хэрээр тэд дахин нутагтаа буцав.
- 8 Мөн гурван зуун жаран хоёр дахь онд тэд тулалдахаар дахин уруудан ирэв. Мөн бид тэднийг дахин ялж, мөн тэднээс агуу олныг хөнөөж, мөн тэдний үхэгсэд тэнгист хаягдсан буюу.

## Mormon 3

And it came to pass that the Lamanites did not come to battle again until ten years more had passed away. And behold, I had employed my people, the Nephites, in preparing their lands and their arms against the time of battle.

And it came to pass that the Lord did say unto me: Cry unto this people—Repent ye, and come unto me, and be ye baptized, and build up again my church, and ye shall be spared.

And I did cry unto this people, but it was in vain; and they did not realize that it was the Lord that had spared them, and granted unto them a chance for repentance. And behold they did harden their hearts against the Lord their God.

And it came to pass that after this tenth year had passed away, making, in the whole, three hundred and sixty years from the coming of Christ, the king of the Lamanites sent an epistle unto me, which gave unto me to know that they were preparing to come again to battle against us.

And it came to pass that I did cause my people that they should gather themselves together at the land Desolation, to a city which was in the borders, by the narrow pass which led into the land southward.

And there we did place our armies, that we might stop the armies of the Lamanites, that they might not get possession of any of our lands; therefore we did fortify against them with all our force.

And it came to pass that in the three hundred and sixty and first year the Lamanites did come down to the city of Desolation to battle against us; and it came to pass that in that year we did beat them, insomuch that they did return to their own lands again.

And in the three hundred and sixty and second year they did come down again to battle. And we did beat them again, and did slay a great number of them, and their dead were cast into the sea.

- 9 Мөн эдүгээ, миний хүмүүс, нифайчуудын үйлдсэн энэ агуу зүйлийн улмаас, тэд хүчиндээ сагсуурч эхлэн, мөн тэнгэрийн өмнө, дайснуудаараа хөнөөгдсөн ах дүүсийнхээ цусны өшөөг тэд авах болно хэмээн тангараглаж эхлэв.
- 10 Мөн тэд дайсныхаа эсрэг тулалдахаар явж мөн уг нутгийн гадаргуу дээрээс арилгах болно хэмээн тэд тэнгэрээр, мөн түүнчлэн Бурханы сэнтийгээр тангараглаж байв.
- 11 Мөнхүү улиран тохиох дор би, Мормон, тэдний ёсон бус мөн жигшүүрт хэргийн улмаас, энэ цагаас энэ хүмүүсийн ахлагч бөгөөд удирдагч байхаас бүрнээ татгалзав.
- 12 Болгоогтун, би тэднийг удирдсан, тэдний ёс бус үйл байсан хэдий ч би тэднийг олон удаа тулалдаанд удирдсан, мөн надад байсан Бурханы хайрын дагуу тэднийг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг байв; мөн бодгаль минь өөрийн Бурханд тэдний төлөө бүх өдрийн уртад залбиралд цутгагдсан билээ; гэсэн хэдий ч, тэдний зүрх сэтгэл хатуугийн улмаас, энэ нь итгэлгүй байв.
- 13 Мөн гурвантаа би тэднийг дайснуудынх нь гараас гаргаж авав, мөн тэд нүглүүдээсээ наманчилсангүй.
- 14 Мөн тэд дайсныхаа эсрэг тулалдахаар явж, мөн ахан дүүсийнхээ цусны өшөөг авна хэмээн, бидний Их Эзэн мөн Аврагч Есүс Христээр тэдэнд хориглогдсон тэр бүгдээр тэд тангарагласны дараа, болгоогтун Их Эзэний дуу хоолой надад ирж, хэлсэн нь:
- 15 Өшөө авалт бол минийх, мөн би хариу төлөх болно; мөн би тэднийг чөлөөлсний дараа энэ хүмүүс наманчлаагүйн улмаас, болгоогтун, тэд дэлхийн гадаргуу дээрээс арилгагдах болно.
- 16 Мөнхүү улиран тохиох дор би дайснуудынхаа эсрэг явахыг бүрнээ татгалзав; мөн бүр Их Эзэн надад зарлиг болсончлон би үйлдэв; мөн ирэх зүйлсийн талаар гэрчилсэн Сүнсний үзүүлэлтүүдийн дагуу, би харсан мөн сонссон тэдгээр зүйлийг дэлхийд үзүүлэхээр оролцохгүй нэгэн гэрч болон зогссон бөлгөө.
- 17 Тиймийн тул би харийнхан та нарт хандан бичиж байна, мөн түүнчлэн Израилын угсааныхан та нарт, уг ажил ундрахад, та нар өвийнхөө нутаг тийш буцаж очихоор бэлтгэхээр завдаж байх болно;

And now, because of this great thing which my people, the Nephites, had done, they began to boast in their own strength, and began to swear before the heavens that they would avenge themselves of the blood of their brethren who had been slain by their enemies.

And they did swear by the heavens, and also by the throne of God, that they would go up to battle against their enemies, and would cut them off from the face of the land.

And it came to pass that I, Mormon, did utterly refuse from this time forth to be a commander and a leader of this people, because of their wickedness and abomination.

Behold, I had led them, notwithstanding their wickedness I had led them many times to battle, and had loved them, according to the love of God which was in me, with all my heart; and my soul had been poured out in prayer unto my God all the day long for them; nevertheless, it was without faith, because of the hardness of their hearts.

And thrice have I delivered them out of the hands of their enemies, and they have repented not of their sins.

And when they had sworn by all that had been forbidden them by our Lord and Savior Jesus Christ, that they would go up unto their enemies to battle, and avenge themselves of the blood of their brethren, behold the voice of the Lord came unto me, saying:

Vengeance is mine, and I will repay; and because this people repented not after I had delivered them, behold, they shall be cut off from the face of the earth.

And it came to pass that I utterly refused to go up against mine enemies; and I did even as the Lord had commanded me; and I did stand as an idle witness to manifest unto the world the things which I saw and heard, according to the manifestations of the Spirit which had testified of things to come.

Therefore I write unto you, Gentiles, and also unto you, house of Israel, when the work shall commence, that ye shall be about to prepare to return to the land of your inheritance;

- 18 Тийм ээ, болгоогтун, дэлхийн бүх хязгааруудад; тийм ээ, Иерусалимын нутагт шавь нараа болгож Есүсийн сонгосон тэр арван хоёроор үйлүүдийн дагуу шүүгдэж болох, Израилын арван хоёр овгийнхон та нарт хандан бичиж байна.
- 19 Мөн энэ хүмүүсийн үлдэгдэлд хандан түүнчлэн бичиж байна би, энэ нутагт Есүсийн сонгосон арванхоёроор түүнчлэн шүүгдэх тэдэнд; мөн тэд Иерусалимын нутагт Есүсийн сонгосон арванхоёроор шүүгдэх болно.
- 20 Мөн эдгээр зүйлсийг Сүнс надад үзүүлж байна; тиймийн тул та бүгдэд бичиж байна би. Мөн энэ шалтгааны улмаас та нарт бичиж байна би, та нар бүгд Христийн шүүлтийн суудлын өмнө зогсох ёстойгоо та нар, тийм ээ, Адамын хүмүүний бүх гэр бүлд хамрагддаг бодгаль болгон мэдэж болохын тулд; мөн та нар өөрсдийн үйлүүдээр, тэдгээр нь сайн эсвээс хилэнцэт байлаа ч, шүүгдэхээр зогсох ёстой;
- 21 Мөн түүнчлэн та нарын дунд байх Есүс Христийн сайн мэдээнд та нар итгэж болохын тулд; мөн түүнчлэн Их Эзэний гэрээт хүмүүс болох иудейчүүд, тэдний хөнөөсөн Есүсийг, чухамхүү Христ мөн чухамхүү Бурхан хэмээн гэрчлэх, тэдний харсан мөн сонсон түүнээс өөр нэгэн гэрчтэй байхын тулд буюу.
- 22 Мөн дэлхийн бүх хязгаарууд та нар наманчилж мөн Христийн шүүлтийн суудлын өмнө зогсохоор бэлтгэхийг ятгаж чадаасай билээ би.

Yea, behold, I write unto all the ends of the earth; yea, unto you, twelve tribes of Israel, who shall be judged according to your works by the twelve whom Jesus chose to be his disciples in the land of Jerusalem.

And I write also unto the remnant of this people, who shall also be judged by the twelve whom Jesus chose in this land; and they shall be judged by the other twelve whom Jesus chose in the land of Jerusalem.

And these things doth the Spirit manifest unto me; therefore I write unto you all. And for this cause I write unto you, that ye may know that ye must all stand before the judgment-seat of Christ, yea, every soul who belongs to the whole human family of Adam; and ye must stand to be judged of your works, whether they be good or evil;

And also that ye may believe the gospel of Jesus Christ, which ye shall have among you; and also that the Jews, the covenant people of the Lord, shall have other witness besides him whom they saw and heard, that Jesus, whom they slew, was the very Christ and the very God.

And I would that I could persuade all ye ends of the earth to repent and prepare to stand before the judgment-seat of Christ.

## Мормон 4

- 1 Мөнхүү эдүгээ улиран тохиох дор гурван зуун жаран гурав дахь онд нифайчууд леменчүүдийн эсрэг их цэрэгтэйгээ, Эзгүйрэлийн нутгаас гаран, тулалдахаар өгсөн одов.
- 2 Мөнхүү улиран тохиох дор нифайчуудын их цэрэг дахин Эзгүйрэлийн нутагт хүртэл ухраагдав. Мөн тэднийг туйлдсан хэвээр байхад нь, леменчүүдийн шинэхэн их цэрэг тэдэн дээр ирэв; мөн тэд ноцтой тулалдаанд орж, үүний хэрээр леменчүүд Эзгүйрэл хотыг эзэмшилдээ авч, мөн нифайчуудын олныг хөнөөн, мөн олон олзлогдогсдыг авсан бөлгөө.
- 3 Мөн үлдсэн нь зугтаж мөн Тианкум хотын оршин суугчидтай нэгдэв. Эдүгээ Тианкум хот тэнгисийн эргийн ойролцоо хилийн тэнд байх ажээ; мөн энэ нь түүнчлэн Эзгүйрэл хотын ойр байв.
- 4 Мөн нифайчуудын их цэрэг леменчүүдийн өөдөөс явсан учир тэд цохигдож эхлэв; учир нь тэгээгүй байсан аваас, леменчүүд тэднийг давах хүчтэй байж чадахгүй байв.
- 5 Гэвч, болгоогтун, Бурханы шүүлтүүд ёс бусыг үйлдэгчдийг дийлэх болно; мөн ёс бусыг үйлдэгчдээр ёс бусыг үйлдэгчид нь шийтгэгддэг; учир нь хүмүүний үрсийн зүрх сэтгэлийг цус урсгахад хүргэн өдөөн хатгадаг нь ёс бусыг үйлдэгчид юм.
- 6 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Тианкум хотын эсрэг ирэх бэлтгэлээ базаав.
- 7 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран дөрөв дэх онд леменчүүд, тэд түүнчлэн Тианкум хотыг эзэмшилдээ авч болохын тулд, Тианкум хотын эсрэг ирэв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд нифайчуудад ялагдан мөн ухрав. Мөн нифайчууд, тэд леменчүүдийг дахин буцааснаа хараад, тэд дахин өөрсдийн хүчинд сагсуурав; мөн тэд өөрсдийн хүчээр урагшилж, мөн Эзгүйрэл хотыг дахин эзэмшилдээ авсан ажгуу.
- 9 Мөн эдүгээ эдгээр бүх зүйлүүд үйлдэгдэж, мөн нифайчууд болон леменчүүдийн аль аль талд мянга мянга нь хөнөөгджээ.

## Mormon 4

And now it came to pass that in the three hundred and sixty and third year the Nephites did go up with their armies to battle against the Lamanites, out of the land Desolation.

And it came to pass that the armies of the Nephites were driven back again to the land of Desolation. And while they were yet weary, a fresh army of the Lamanites did come upon them; and they had a sore battle, insomuch that the Lamanites did take possession of the city Desolation, and did slay many of the Nephites, and did take many prisoners.

And the remainder did flee and join the inhabitants of the city Teancum. Now the city Teancum lay in the borders by the seashore; and it was also near the city Desolation.

And it was because the armies of the Nephites went up unto the Lamanites that they began to be smitten; for were it not for that, the Lamanites could have had no power over them.

But, behold, the judgments of God will overtake the wicked; and it is by the wicked that the wicked are punished; for it is the wicked that stir up the hearts of the children of men unto bloodshed.

And it came to pass that the Lamanites did make preparations to come against the city Teancum.

And it came to pass in the three hundred and sixty and fourth year the Lamanites did come against the city Teancum, that they might take possession of the city Teancum also.

And it came to pass that they were repulsed and driven back by the Nephites. And when the Nephites saw that they had driven the Lamanites they did again boast of their own strength; and they went forth in their own might, and took possession again of the city Desolation.

And now all these things had been done, and there had been thousands slain on both sides, both the Nephites and the Lamanites.

- 10 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран зургаан жил улиран одож, мөн леменчүүд нифайчуудын дээр тулалдахаар дахин ирэв; мөн нифайчууд өөрсдийн үйлдсэн хилэнцээс наманчлаагүй хэвээр байв, харин ёс бусын үйлээ үргэлжлүүлсээр байсан ажгуу.
- 11 Мөн хэлээр тайлбарлахад, эсвээс хүмүүнд нифайчууд мөн леменчүүд аль аль хүмүүсийн дунд байсан цус мөн хядааны аймшигт дүр зургийн төгс дүрслэлийг бичих нь боломжгүй юм; мөн зүрх сэтгэл болгон хатуурав, тиймээс тэд цус урсгахдаа байнга баясдаг байв.
- 12 Мөн Их Эзэний үгсийн дагуу, энэ хүмүүсийн дунд байсан лугаа адил, тийм агуу ёсон бусын үйл Лихайн бүх хүүхдүүдийн дунд ч, бас бүр Израилын бүх угсааны дунд ч байсангүй.
- 13 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд Эзгүйрэл хотыг эзэмшилдээ авч, мөн энэ нь тэдний тоо нифайчуудын тоог давамгайлсны улмаас буюу.
- 14 Мөн тэд түүнчлэн Тианкум хотын эсрэг урагш давшиж, мөн оршин суугчдыг нь тэндээс хөөв, мөн эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн аль алинаас олон олзлогдогсдыг авч, мөн тэднийг хиймэл бурхаддаа тахил болгон өргөв.
- 15 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун жаран долоо дахь онд, леменчүүд тэдний эмэгтэйчүүд мөн тэдний хүүхдүүдийг золиосолсны улмаас, нифайчууд хилэгнэж, иймээс тэд агуу их хилэнтэйгээр леменчүүдийн эсрэг явж, үүний хэрээр тэд леменчүүдийг дахин дийлж, мөн тэднийг нутгаасаа үлдэн хөөв.
- 16 Мөн гурван зуун далан тав дахь он хүртэл леменчүүд нифайчуудын эсрэг дахин ирсэнгүй.
- 17 Мөн энэхүү онд тэд өөрсдийн бүх хүчээр нифайчуудын эсрэг дахин ирэв; мөн тэдний тооны агуу ихийн улмаас тэд тоологдоогүй буюу.
- 18 Мөн энэ цагаас эхлэн нифайчууд леменчүүдийн дээгүүр хүч чадлыг олсонгүй, харин нарны өмнөх шүүдэр лугаа адил тэднээр арчигдах болов.

And it came to pass that the three hundred and sixty and sixth year had passed away, and the Lamanites came again upon the Nephites to battle; and yet the Nephites repented not of the evil they had done, but persisted in their wickedness continually.

And it is impossible for the tongue to describe, or for man to write a perfect description of the horrible scene of the blood and carnage which was among the people, both of the Nephites and of the Lamanites; and every heart was hardened, so that they delighted in the shedding of blood continually.

And there never had been so great wickedness among all the children of Lehi, nor even among all the house of Israel, according to the words of the Lord, as was among this people.

And it came to pass that the Lamanites did take possession of the city Desolation, and this because their number did exceed the number of the Nephites.

And they did also march forward against the city Teancum, and did drive the inhabitants forth out of her, and did take many prisoners both women and children, and did offer them up as sacrifices unto their idol gods.

And it came to pass that in the three hundred and sixty and seventh year, the Nephites being angry because the Lamanites had sacrificed their women and their children, that they did go against the Lamanites with exceedingly great anger, insomuch that they did beat again the Lamanites, and drive them out of their lands.

And the Lamanites did not come again against the Nephites until the three hundred and seventy and fifth year.

And in this year they did come down against the Nephites with all their powers; and they were not numbered because of the greatness of their number.

And from this time forth did the Nephites gain no power over the Lamanites, but began to be swept off by them even as a dew before the sun.

- 19 Мөнхүү улиран тохиох дор леменчүүд дахин  
Эзгүйрэл хотын эсрэг уруудан ирэв; мөн Эзгүйрэл  
нутагт үлэмж ноцтой тулалдаан болж, түүнд тэд ни-  
файчуудыг дийлэв.
- 20 Мөн тэд дахин тэдний өмнө зугтаж, мөн тэд  
Боазын хотод ирэв; мөн тэнд тэд үлэмж зоригтой-  
гоор леменчүүдийн эсрэг зогсож, үүний хэрээр ле-  
менчүүд, тэд хоёр дахь удаагаа дахин ирэх хүртлээ  
тэднийг дийлсэнгүй.
- 21 Мөн тэднийг хоёр дахь удаагаа ирэхэд, нифайчууд  
хөөгдөн мөн үлэмж агуу аллагаар хүйс тэмтрүүлэв;  
тэдний эмэгтэйчүүд мөн тэдний хүүхдүүд дахин  
хиймэл шүтээнүүдэд золиослогдов.
- 22 Мөнхүү улиран тохиох дор нифайчууд дахин тэд-  
ний өмнө, хотод ч тосгодод ч байсан бүх оршин  
суугчдыг өөрсөдтэйгээ аван, зугтав.
- 23 Мөн эдүгээ би, Мормон, леменчүүд уг нутгийг  
сүйрүүлэх гэж буйг харсан учир, тиймийн тул би  
Шим толгойд очин, мөн Их Эзэний төлөө  
Аммароны нуусан бүх цэдгүүдийг авав.

And it came to pass that the Lamanites did come  
down against the city Desolation; and there was an ex-  
ceedingly sore battle fought in the land Desolation, in  
the which they did beat the Nephites.

And they fled again from before them, and they came  
to the city Boaz; and there they did stand against the  
Lamanites with exceeding boldness, insomuch that the  
Lamanites did not beat them until they had come again  
the second time.

And when they had come the second time, the  
Nephites were driven and slaughtered with an exceed-  
ingly great slaughter; their women and their children  
were again sacrificed unto idols.

And it came to pass that the Nephites did again flee  
from before them, taking all the inhabitants with them,  
both in towns and villages.

And now I, Mormon, seeing that the Lamanites were  
about to overthrow the land, therefore I did go to the  
hill Shim, and did take up all the records which  
Ammaron had hid up unto the Lord.

## Мормон 5

- 1 Мөнхүү улиран тохиох дор би урагш нифайчуудын дунд явж, мөн би тэдэнд хойшид туслахгүй хэмээн үйлдсэн тангаргаа наманчлав; мөн тэд дахин их цэргийнхээ удирдлагыг надад өгөв, учир нь тэд намайг зовлон зүдгүүрээс нь тэднийг чөлөөлж чадах мэтээр над өөд харж байв.
- 2 Гэвч болгоогтун, би найдвар үгүй байв, учир нь тэдний дээр ирэх Их Эзэний шүүлтүүдийг би мэдсэн юм; учир нь тэд алдсуудаа наманчилсангүй, харин өөрсдийг нь бүтээсэн Нэгэнийг дуудалгүйгээр амийнхаа төлөө тэмцсэн ажгуу.
- 3 Мөнхүү улиран тохиох дор бид Иорданы хот тийш зугтсан үед леменчүүд бидний эсрэг ирэв; гэвч болгоогтун, тэд ухраагдсанаас тэр үед тэд хотыг авсангүй.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэд дахин бидний эсрэг ирж, мөн бид хотыг хадгалан хамгаалав. Мөн бидний нутгийн оршин суугчдыг устгахаар бидний өмнө орших нутаг тийш орж чадахгүй хэмээн тэднийг тусгаарласан бэхлэлтүүд болох, нифайчуудаар хадгалагдан хамгаалагдсан өөр бусад хотууд байв.
- 5 Гэвч улиран тохиох дор бидний дайрч гарсан, мөн оршин суугчид нь цуглуулагдаагүй бүх нутгууд леменчүүдээр устгагдав, мөн тэдний суурингууд, мөн тосгод, мөн хотууд галд шатаагдав; мөн тийн гурван зуун далан есөн жил улирч одов.
- 6 Мөнхүү улиран тохиох дор гурван зуун ная дахь онд леменчүүд бидний эсрэг тулалдахаар дахин ирж, мөн бид тэдний эсрэг зоригтойгоор зогсов; гэвч энэ бүхэн бүгд хий хоосон байв, учир нь тэд нифайчуудыг хөл дороо дэвсэлсэн тэдний тоо тийм агуу байлаа.
- 7 Мөнхүү улиран тохиох дор бид дахин зугтаж, мөн гүйх нь леменчүүдийнхээс шаламгай байсан тэд амьд гарч, мөн леменчүүдийнхийг давж гараагүй тэд арчигдаж мөн устгагдав.

## Mormon 5

And it came to pass that I did go forth among the Nephites, and did repent of the oath which I had made that I would no more assist them; and they gave me command again of their armies, for they looked upon me as though I could deliver them from their afflictions.

But behold, I was without hope, for I knew the judgments of the Lord which should come upon them; for they repented not of their iniquities, but did struggle for their lives without calling upon that Being who created them.

And it came to pass that the Lamanites did come against us as we had fled to the city of Jordan; but behold, they were driven back that they did not take the city at that time.

And it came to pass that they came against us again, and we did maintain the city. And there were also other cities which were maintained by the Nephites, which strongholds did cut them off that they could not get into the country which lay before us, to destroy the inhabitants of our land.

But it came to pass that whatsoever lands we had passed by, and the inhabitants thereof were not gathered in, were destroyed by the Lamanites, and their towns, and villages, and cities were burned with fire; and thus three hundred and seventy and nine years passed away.

And it came to pass that in the three hundred and eightieth year the Lamanites did come again against us to battle, and we did stand against them boldly; but it was all in vain, for so great were their numbers that they did tread the people of the Nephites under their feet.

And it came to pass that we did again take to flight, and those whose flight was swifter than the Lamanites' did escape, and those whose flight did not exceed the Lamanites' were swept down and destroyed.



- 8 Мөн эдүгээ болгоогтун, би, Мормон, миний нүдний өмнө тавигдсан лугаа адил, цус мөн хядааны тийм аймшигт дүр зургийг тэдний өмнө гаргаснаар хүмүүсийн сэтгэлийг тарчилгахыг би үл хүснэ; гэвч эдгээр зүйлсүүд гарцаагүй мэдүүлэгдэх ёстой, мөн нуугдсан бүх зүйл байшингийн дээвар дээрээс илчлэгдэх ёстойг би мэдэх учир—
- 9 Мөн түүнчлэн эдгээр зүйлсийн мэдлэг нь эдгээр хүмүүсийн үлдэгдэлд, мөн түүнчлэн энэ хүмүүсийг тараана хэмээн, мөн энэ хүмүүс тэдний дунд хэн ч хэмээн үл тооцогдоно хэмээн Их Эзэн хэлсэн харийнханд ирэх ёстойг—тиймийн тул, би хүлээн авсан зарлигийнхаа улмаас, өөрийн харсан тэр зүйлсийн бүрэн шастирыг өгөхийг үл зүрхлэхийн учир, мөн түүнчлэн энэ хүмүүсийн ёс бус үйлээс болж та нар дэндүү их харуусалтай байхгүйн тулд би нэгэн богино хураангуйллыг бичье.
- 10 Мөн эдүгээ болгоогтун, үүнийг би тэдний үрсэд, мөн түүнчлэн Израилын угсаанд санаа тавих, адислалууд нь хаанаас ирдгийг ухаарч мөн мэдэх харийнханд ярьж байна.
- 11 Тийм нь Израилын угсааны гай гамшгийн улмаас харуусахыг би мэдэхийн учир буюу; тийм ээ, тэд энэ хүмүүсийн устгалын төлөө харуусах болно; тэд Есүсийн мутарт тэврэгдэж болохын тулд энэ хүмүүс наманчилсангүйд тэд харуусах болно.
- 12 Эдүгээ эдгээр зүйлс нь Иаковын угсааны үлдэгдэлд бичигдсэн бөлгөө; мөн ёс бус байдал нь тэдгээрийг урагш тэдэнд авчрахгүй нь Бурханд мэдэгддэгийн улмаас, тэдгээр нь энэ маягаар бичиглэгдсэн буюу; мөн тэдгээр нь түүний зохих цагт урагш ирж болохын тулд Их Эзэний төлөө далдлагдах ёстой.
- 13 Мөн миний хүлээн авсан зарлиг энэ болой; мөн болгоогтун, Их Эзэний зарлигийн дагуу, тэрбээр өөрийн мэргэн ухаанд нийцнэ хэмээн үзэх үед, тэдгээр нь гарч ирэх болно.

And now behold, I, Mormon, do not desire to harrow up the souls of men in casting before them such an awful scene of blood and carnage as was laid before mine eyes; but I, knowing that these things must surely be made known, and that all things which are hid must be revealed upon the house-tops—

And also that a knowledge of these things must come unto the remnant of these people, and also unto the Gentiles, who the Lord hath said should scatter this people, and this people should be counted as naught among them—therefore I write a small abridgment, daring not to give a full account of the things which I have seen, because of the commandment which I have received, and also that ye might not have too great sorrow because of the wickedness of this people.

And now behold, this I speak unto their seed, and also to the Gentiles who have care for the house of Israel, that realize and know from whence their blessings come.

For I know that such will sorrow for the calamity of the house of Israel; yea, they will sorrow for the destruction of this people; they will sorrow that this people had not repented that they might have been clasped in the arms of Jesus.

Now these things are written unto the remnant of the house of Jacob; and they are written after this manner, because it is known of God that wickedness will not bring them forth unto them; and they are to be hid up unto the Lord that they may come forth in his own due time.

And this is the commandment which I have received; and behold, they shall come forth according to the commandment of the Lord, when he shall see fit, in his wisdom.

14 Мөн болгоогтун, тэдгээр нь иудейчүүдийн үл итгэх тэдэнд очих болно; мөн энэ зорилгын учир тэдгээр нь очих болно—тэд, Есүс бол Христ, амьд Бурханы Хүү гэдэгт ятгуулагдаж болохын тул; өөрийн хамгийн Хайртаар дамжуулан, өөрийн гэрээг биелүүлэн, Их Эзэн тэдний Бурхан тэдэнд соёрхсон, тэдний өвийн нутагт иудейчүүдийг, эсвээс Израилын бүх угсааг сэргээснээр, Эцэг өөрийн агуу хийгээд мөнхийн зорилгыг биелүүлж болохын тулд болой;

15 Мөн түүнчлэн, харийнханаас тэдэнд очих түүний сайн мэдээнд энэ хүмүүсийн үрс илүү бүрнээр итгэж болохын тулд буюу; учир нь энэ хүмүүс тараагдаж, мөн бидний дунд байсан түүний ямар ч дүрслэлээс, тийм ээ, бүр леменчүүдийн дунд байснаас ч илүүгээр харанхуй, зэвүүцэм, мөн буртаглагдсан хүмүүс болох болно, мөн энэ нь тэдний итгэлгүй байдал болоод хиймэл шүтээн шүтдэгийн улмаас буюу.

16 Учир нь болгоогтун, Их Эзэний Сүнс тэдний эцэг дээдсийн төлөө зүтгэхээ аль хэдийн больсон ажгуу; мөн тэд дэлхийд Христ болон Бурхангүйгээр байгаа болой; мөн тэд салхинд туугдах будааны хальс лугаа адил хөөгдөж байгаа билээ.

17 Тэд нэгэн цагт бахдам сайхан хүмүүс байв, мөн тэд Христийг өөрсдийн хоньчин болгосон байв; тийм ээ, тэд бүр Бурхан Эцэгээр удирдуулдаг байв.

18 Гэвч эдүгээ, болгоогтун, тэд Сатанаар, бүр салхинд туугдах будааны хальс лугаа адил, эсвээс далбаа эс бөгөөс зангуугүй, эс бөгөөс түүнийг жолоодох юу ч үгүйгээр давалгаан дээр шидэгдэх хөлөг лугаа адил хөтлүүлж байгаа бөлгөө; мөн бүр тэд түүний адилаар байгаа болой.

19 Мөн болгоогтун, тэд уг нутагт хүлээн авч болох байсан тэдгээр адислалуудыг уг нутгийг эзэмших учиртай харийнханы улмаас Их Эзэн хадгалсан бөлгөө.

20 Гэвч болгоогтун, улиран тохиох дор тэд харийнханаар хөөгдөж мөн тараагдах болно; мөн тэд харийнханаар хөөгдөж мөн тараагдсаны дараа, болгоогтун, тэгээд Их Эзэн, Абрахамд мөн Израилын бүх угсаанд хийсэн гэрээгээ санах болно.

And behold, they shall go unto the unbelieving of the Jews; and for this intent shall they go—that they may be persuaded that Jesus is the Christ, the Son of the living God; that the Father may bring about, through his most Beloved, his great and eternal purpose, in restoring the Jews, or all the house of Israel, to the land of their inheritance, which the Lord their God hath given them, unto the fulfilling of his covenant;

And also that the seed of this people may more fully believe his gospel, which shall go forth unto them from the Gentiles; for this people shall be scattered, and shall become a dark, a filthy, and a loathsome people, beyond the description of that which ever hath been amongst us, yea, even that which hath been among the Lamanites, and this because of their unbelief and idolatry.

For behold, the Spirit of the Lord hath already ceased to strive with their fathers; and they are without Christ and God in the world; and they are driven about as chaff before the wind.

They were once a delightsome people, and they had Christ for their shepherd; yea, they were led even by God the Father.

But now, behold, they are led about by Satan, even as chaff is driven before the wind, or as a vessel is tossed about upon the waves, without sail or anchor, or without anything wherewith to steer her; and even as she is, so are they.

And behold, the Lord hath reserved their blessings, which they might have received in the land, for the Gentiles who shall possess the land.

But behold, it shall come to pass that they shall be driven and scattered by the Gentiles; and after they have been driven and scattered by the Gentiles, behold, then will the Lord remember the covenant which he made unto Abraham and unto all the house of Israel.

21 Мөн түүнчлэн Их Эзэн тэдний төлөө түүнд өргөгдсөн зөв шударгыг үйлдэгчдийн залбирлуудыг санах болно.

22 Мөн тэгвэл, Ай Харийнхан та нар, та нар наманчилж хилэнцэт замаасаа эргэхээс бусдаар, Бурханы хүчний өмнө хэрхэн зогсож чадах билээ

23 Бурханы мутарт гэдгээ та нар мэдэхгүй гэж үү? Тэрбээр бүх хүчийг эзэмшдэг, мөн түүний агуу удирдлагаар газар дэлхий хуйлмал бичиг лугаа адил хуйлагдах болно гэдгийг та нар мэдэхгүй гэж үү

24 Тиймийн тул, наманчлагтун та нар, мөн шударга ёсонд тэрбээр та нарын эсрэг ирэх вий хэмээн —Иаковын үрийн нэгэн үлдэгдэл та нарын дунд арслан лугаа адил явж, мөн та нарыг хэдэн хэсэг тасчин, мөн чөлөөлөх хэн ч үгүй байх болуузай хэмээн түүний өмнө өөрсдийгөө даруусга.

And also the Lord will remember the prayers of the righteous, which have been put up unto him for them.

And then, O ye Gentiles, how can ye stand before the power of God, except ye shall repent and turn from your evil ways?

Know ye not that ye are in the hands of God? Know ye not that he hath all power, and at his great command the earth shall be rolled together as a scroll?

Therefore, repent ye, and humble yourselves before him, lest he shall come out in justice against you—lest a remnant of the seed of Jacob shall go forth among you as a lion, and tear you in pieces, and there is none to deliver.

## Мормон 6

- 1 Мөн эдүгээ өөрийн хүмүүс, нифайчуудын устгалын талаарх цэдгээ би өндөрлөө. Мөнхүү улиран тохиох дор бид леменчүүдийн өмнө урагш жагсан одсон буюу.
- 2 Мөн би, Мормон, леменчүүдийн хаанд захидал бичиж, мөн бид өөрсдийн хүмүүсийг Кумора хэмээн нэрлэгдэх гүвээний ойр, Куморагийн нутагт цуглуулахыг бидэнд зөвшөөрөхийг түүнээс хүсэмжлэн, мөн тэнд бид тэдэнтэй тулалдаанд орохыг хэлэв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор миний хүсэмжилсэн түүнийг леменчүүдийн хаан надад зөвшөөрсөн бөлгөө.
- 4 Мөнхүү улиран тохиох дор бид Куморагийн нутаг хүртэл жагсан очиж, мөн бид Кумора гүвээний эргэн тойронд бид майхнуудаа босгов; мөн энэ нь олон ус, мөн голууд, мөн усан оргилууд бүхий нутаг байв; мөн энд бид леменчүүдийн дээгүүр давамгай байдлыг олж авна хэмээн найдаж байв.
- 5 Мөн гурван зуун наян дөрвөн жил улирч одоход, бид өөрсдийн хүмүүсийн үлдэгдлийг бүгдийг Куморагийн нутагт цуглуулав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор бид бүх хүмүүсээ нэгтгэн, Куморагийн нутагт цуглуулсны дараа, болгоогтун би, Мормон, нас өндөр болж эхлэв; мөн энэ нь миний хүмүүсийн сүүлчийн тулалдаан болохыг мэдсэн учир, мөн манай эцэг дээдсээр доош гардуулагдан дамжуулагдсан, ариун нандин болох эл цэдгүүдийг леменчүүдийн гарт орохыг эс хүлцэхийг би Их Эзэнээр зарлиг болгуулсан учир, (леменчүүд тэдгээрийг устгахын учир) тиймийн тул би энэхүү цэдгийг Нифайн ялтсуудаас үйлдэж, мөн би хүү Моронайдаа өгсөн эдгээр цөөн хэдэн ялтсаас бусад, Их Эзэний мутраар надад итгэмжлэгдсэн бүх цэдгүүдийг Кумора гүвээнд нуув.
- 7 Мөнхүү улиран тохиох дор миний хүмүүс, өөрсдийн эхнэр мөн өөрсдийн хүүхдүүдийн хамт, эдүгээ леменчүүдийн их цэргийг өөрсдийн зүг давшихыг харж байв; мөн ёс бус бүгдийн цээжийг дүүргэх үхлийн аюумшигт айдастайгаар, тэднийг хүлээн авахаар тэд хүлээж байв.

## Mormon 6

And now I finish my record concerning the destruction of my people, the Nephites. And it came to pass that we did march forth before the Lamanites.

And I, Mormon, wrote an epistle unto the king of the Lamanites, and desired of him that he would grant unto us that we might gather together our people unto the land of Cumorah, by a hill which was called Cumorah, and there we could give them battle.

And it came to pass that the king of the Lamanites did grant unto me the thing which I desired.

And it came to pass that we did march forth to the land of Cumorah, and we did pitch our tents around about the hill Cumorah; and it was in a land of many waters, rivers, and fountains; and here we had hope to gain advantage over the Lamanites.

And when three hundred and eighty and four years had passed away, we had gathered in all the remainder of our people unto the land of Cumorah.

And it came to pass that when we had gathered in all our people in one to the land of Cumorah, behold I, Mormon, began to be old; and knowing it to be the last struggle of my people, and having been commanded of the Lord that I should not suffer the records which had been handed down by our fathers, which were sacred, to fall into the hands of the Lamanites, (for the Lamanites would destroy them) therefore I made this record out of the plates of Nephi, and hid up in the hill Cumorah all the records which had been entrusted to me by the hand of the Lord, save it were these few plates which I gave unto my son Moroni.

And it came to pass that my people, with their wives and their children, did now behold the armies of the Lamanites marching towards them; and with that awful fear of death which fills the breasts of all the wicked, did they await to receive them.

- 8 Мөнхүү улиран тохиох дор тэд бидний эсрэг тулалдахаар ирж, мөн тэдний тооны агуугийн улмаас бодгаль бүр айдсаар дүүрсэн байв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд миний хүмүүс дээр илдтэйгээр, мөн нум, мөн сум, мөн сүх, мөн бүх л төрлийн дайны зэвсэгтэйгээр буун ирэв ээ.
- 10 Мөнхүү улиран тохиох дор миний эрчүүд хиар цохигдож, тийм ээ, бүр надтай хамт байсан миний арван мянга, мөн би дунд нь шархдан унасан буюу; мөн тэд намайг өнгөрөн явснаас амийг минь төгсгөл болгосонгүй.
- 11 Мөн бидний хорин дөрвөөс (дунд нь миний хүү Моронай байв) бусад миний бүх хүмүүсийг тэд дайран гараад мөн хиар цохьсны дараа, мөн бид өөрсдийн хүмүүсийн үхэгсдийн ард амь гарч үлдсэний дараа, леменчүүд буудалласан газартаа буцахад, маргааш өдөр нь урьд нь надаар удирдуулж асан хүмүүсийнхээ хиар цохиулсан арван мянгыг бид Кумора гүвээний оройгоос болгоов.
- 12 Мөн бид түүнчлэн миний хүү Моронайгаар удирдуулсан арван мянгыг болгоосон буюу.
- 13 Мөн болгоогтун, Гидгиддонайн арван мянга, мөн тэрбээр дунд нь унасан байв.
- 14 Мөн Лама мөн өөрийн арван мянгатай унажээ; мөн Гилгал өөрийн арван мянгатай унажээ; мөн Лимха өөрийн арван мянгатай унаж; мөн Жениам өөрийн арван мянгатай унасан байв; мөн Кюмениха, мөн Моронайха, мөн Антионум, мөн Шиблом, мөн Шем, мөн Жош тус бүрийн арван мянгатай унасан ажгуу.
- 15 Мөнхүү улиран тохиох дор өөр өөрсдийн арван мянгын хамт, илдэнд унасан өөр арав байв; тийм ээ, надтай хамт байсан тэдгээр хорин дөрөв, мөн түүнчлэн өмнөд нутгуудын зүг дүрвэсэн цөөн хэд, мөн леменчүүдэд урвасан цөөн хэдээс бусад нь бүр миний бүх хүмүүс унажээ; мөн уг нутагт ялзраан, мөн үйрүүлж бутраан мөн эх дэлхийд нь буцаахаар тэднийг хиаруулсан тэдний гараар орхигдсон учир тэдний цогцос, яс, мөн цус дэлхийн гадаргуу дээр хэвтэж байв.
- 16 Мөн бодгаль минь, хүмүүсийнхээ хөнөөгдсөний улмаас, зовлондоо урагдаж, мөн хашгирав би:

And it came to pass that they came to battle against us, and every soul was filled with terror because of the greatness of their numbers.

And it came to pass that they did fall upon my people with the sword, and with the bow, and with the arrow, and with the ax, and with all manner of weapons of war.

And it came to pass that my men were hewn down, yea, even my ten thousand who were with me, and I fell wounded in the midst; and they passed by me that they did not put an end to my life.

And when they had gone through and hewn down all my people save it were twenty and four of us, (among whom was my son Moroni) and we having survived the dead of our people, did behold on the morrow, when the Lamanites had returned unto their camps, from the top of the hill Cumorah, the ten thousand of my people who were hewn down, being led in the front by me.

And we also beheld the ten thousand of my people who were led by my son Moroni.

And behold, the ten thousand of Gidgiddonah had fallen, and he also in the midst.

And Lamah had fallen with his ten thousand; and Gilgal had fallen with his ten thousand; and Limhah had fallen with his ten thousand; and Jeneum had fallen with his ten thousand; and Cumenihah, and Moronihah, and Antionum, and Shiblom, and Shem, and Josh, had fallen with their ten thousand each.

And it came to pass that there were ten more who did fall by the sword, with their ten thousand each; yea, even all my people, save it were those twenty and four who were with me, and also a few who had escaped into the south countries, and a few who had deserted over unto the Lamanites, had fallen; and their flesh, and bones, and blood lay upon the face of the earth, being left by the hands of those who slew them to molder upon the land, and to crumble and to return to their mother earth.

And my soul was rent with anguish, because of the slain of my people, and I cried:

- 17 Ай хонгорхон та нар, та нар Их Эзэний замаас яхин салж чадаваа! Ай хонгорхон та нар, та нарыг хүлээн авахаар гараа дэлгэн зогссон, Есүсээс та нар хэрхэн татгалзаж чадав аа!
- 18 Болгоогтун, хэрэв та нар үүнийг эс үйлдсэн аваас, та нар унахгүй байсан. Гэвч болгоогтун, та нар унасан, мөн та нарыг алдсандаа гашууднам би.
- 19 Ай хонгорхон хөвгүүд, охид та нар, эцгүүд мөн эхчүүд та нар, мөн нөхрүүд хийгээд эхнэрүүд та нар, хонгорхон та нар, хэрхэн унаж чадаваа та нар!
- 20 Гэвч болгоогтун, та нар үгүй болсон, мөн миний харууслууд та нарыг эргүүлж авчирч эс чадна.
- 21 Мөн та нарын зуурдын байдал үхэшгүйд тавигдана, мөн эдүгээ ялзалдаа муудаж буй эдгээр цогцсууд удахгүй ялзаршгүй цогцос болох ёстой тэр өдөр удахгүй ирнэ; мөн тэгээд та нар Христийн шүүлтийн суудлын өмнө, үйлүүдийнхээ дагуу шүүгдэхээр зогсох ёстой; мөн хэрэв та нар зөв шударга байсан аваас, тэгвэл та нар өөрсдийн тань өмнө одсон эцэг дээдэстэйгээ хамт адислагдах болно.
- 22 Ай та нар энэхүү агуу устгал та нарын дээр ирэхийн өмнө наманчилсан ч болоосой. Гэвч болгоогтун, та нар үгүй болсон, мөн Эцэг, тийм ээ, тэнгэрийн Мөнхийн Эцэг та нарын байдлыг мэднэ; мөн тэрбээр өөрийн шударга ёс хийгээд нигүүлслийн дагуу та нарт үйлддэг бөлгөө.

O ye fair ones, how could ye have departed from the ways of the Lord! O ye fair ones, how could ye have rejected that Jesus, who stood with open arms to receive you!

Behold, if ye had not done this, ye would not have fallen. But behold, ye are fallen, and I mourn your loss.

O ye fair sons and daughters, ye fathers and mothers, ye husbands and wives, ye fair ones, how is it that ye could have fallen!

But behold, ye are gone, and my sorrows cannot bring your return.

And the day soon cometh that your mortal must put on immortality, and these bodies which are now moldering in corruption must soon become incorruptible bodies; and then ye must stand before the judgment-seat of Christ, to be judged according to your works; and if it so be that ye are righteous, then are ye blessed with your fathers who have gone before you.

O that ye had repented before this great destruction had come upon you. But behold, ye are gone, and the Father, yea, the Eternal Father of heaven, knoweth your state; and he doeth with you according to his justice and mercy.

## Мормон 7

- 1 Мөн эдүгээ, болгоогтун, тэд өөрсдийн эцэг дээдсийн зүйлсийг мэдэж болохын тулд, хэрэв Бурхан миний үгсийг тэдэнд өгөх аваас, энэ хүмүүсийн хэлтрүүлэгдсэн үлдэгдэлд би заримыг ярихыг хүснэ; тийм ээ, би та нарт, Израилын угсааны үлдэгдэл та нарт ярьж байна; мөн миний ярих үгс нь эдгээр буюу:
- 2 Та нар Израилын угсааных гэдгээ мэдэгтүн, та нар.
- 3 Та нар наманчлалд ирэх ёстой, эсвээс та нар аврагдаж чадахгүйгээ мэдэгтүн, та нар.
- 4 Та нар дайны зэр зэвсгүүдээ хаяж, мөн цус урсгахад цаашид сэтгэл үл хөөрч, мөн Бурхан та нарт зарлиглахаас бусдаар, тэдгээрийг дахин үл авах ёстойгоо мэдэгтүн, та нар.
- 5 Та нар өөрсдийн эцэг дээдсийн мэдлэгт ирж, мөн өөрсдийн бүх нүглүүд мөн алдсуудаас наманчилж, мөн Есүс Христэд, тэрбээр Бурханы Хүү, мөн тэрбээр иудейчүүдээр хөнөөгдсөн, мөн Эцэгийн хүчээр тэрбээр дахин боссон, тэгснээр тэрбээр булшны дээгүүр ялалт олсон; мөн түүнчлэн үхлийн шаналал түүнд залгигдсан гэдэгт итгэх ёстойгоо мэдэгтүн, та нар.
- 6 Мөн тэрбээр нас барагсдын амилуулалтыг улируулан тохиолгож, тэгснээр хүмүүн түүний шүүлтийн суудлын өмнө зогсохоор босгогдоно гэдэгт.
- 7 Мөн дэлхийн гэтэлгэлийг тэрбээр улируулан тохиолгосон, тэгснээр шүүлтийн өдөр түүний өмнө гэмгүй нь тогтоогдсон тэрэнд, дээдхийн найралд эцэсгүй магтууг нэг Бурхан болох, Эцэгт, мөн Хүүд, мөн Ариун Сүнсэнд, эцэсгүй аз жаргалтай байдлаар дуулахаар түүний хаант улсад Бурханы дэргэд амьдрах нь өгөгдөнө гэдэгт буюу.
- 8 Тиймийн тул наманчлагтун, мөн Есүсийн нэрээр баптисм хүртэгтүн, мөн зөвхөн энэ цэдгээр бус харин түүнчлэн иудейчүүдээс харийнханд ирэх, харийнханаас та нарт ирэх тэр цэдгээр та нарын өмнө тавигдах Христийн сайн мэдээнээс баригтун.

## Mormon 7

And now, behold, I would speak somewhat unto the remnant of this people who are spared, if it so be that God may give unto them my words, that they may know of the things of their fathers; yea, I speak unto you, ye remnant of the house of Israel; and these are the words which I speak:

Know ye that ye are of the house of Israel.

Know ye that ye must come unto repentance, or ye cannot be saved.

Know ye that ye must lay down your weapons of war, and delight no more in the shedding of blood, and take them not again, save it be that God shall command you.

Know ye that ye must come to the knowledge of your fathers, and repent of all your sins and iniquities, and believe in Jesus Christ, that he is the Son of God, and that he was slain by the Jews, and by the power of the Father he hath risen again, whereby he hath gained the victory over the grave; and also in him is the sting of death swallowed up.

And he bringeth to pass the resurrection of the dead, whereby man must be raised to stand before his judgment-seat.

And he hath brought to pass the redemption of the world, whereby he that is found guiltless before him at the judgment day hath it given unto him to dwell in the presence of God in his kingdom, to sing ceaseless praises with the choirs above, unto the Father, and unto the Son, and unto the Holy Ghost, which are one God, in a state of happiness which hath no end.

Therefore repent, and be baptized in the name of Jesus, and lay hold upon the gospel of Christ, which shall be set before you, not only in this record but also in the record which shall come unto the Gentiles from the Jews, which record shall come from the Gentiles unto you.

9 Учир нь болгоогтун, энэ нь та нар түүнд итгэж болно хэмээх зорилготойгоор бичигдсэн юм; мөн хэрэв та нар түүнд итгэх аваас та нар түүнчлэн үүнд итгэх болно; мөн хэрэв та нар үүнд итгэх аваас та нар өөрсдийн эцэг дээдсийн талаар, мөн түүнчлэн тэдний дунд Бурханы хүчээр үйлдэгдсэн гайхамшигт үйлүүдийн талаар та нар мэдэх болно.

10 Мөн та нар Иаковын үрийн нэгэн үлдэгдэл болохоо та нар түүнчлэн мэдэх болно; тиймийн тул та нар анхны гэрээт хүмүүсийн дунд тоологдох буюу; мөн хэрэв та нар Христэд итгэн, мөн бидний Аврагчийн жишээг даган, тэрээр бидэнд зарлиг болгосны дагуу, эхлээд усаар, дараа нь галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртэх аваас, шүүлтийн өдөр та нарын хувьд сайн байх болно. Амен.

For behold, this is written for the intent that ye may believe that; and if ye believe that ye will believe this also; and if ye believe this ye will know concerning your fathers, and also the marvelous works which were wrought by the power of God among them.

And ye will also know that ye are a remnant of the seed of Jacob; therefore ye are numbered among the people of the first covenant; and if it so be that ye believe in Christ, and are baptized, first with water, then with fire and with the Holy Ghost, following the example of our Savior, according to that which he hath commanded us, it shall be well with you in the day of judgment. Amen.



## Мормон 8

- 1 Болгоогтун Моронай, би, өөрийн эцэг Мормоны цэдгийг дуусгая. Болгоогтун, би эцгээрээ зарлиг болгуулсан, бичих зөвхөн хэдхэн зүйлс надад буй.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Кумора дахь агуу мөн нүсэр тулалдааны дараа, болгоогтун, өмнө зүгийн нутаг тийш дүрвэсэн нифайчууд леменчүүдээр, тэд бүгд устгагдах хүртлээ мөрдөгдсөн болой.
- 3 Мөн миний эцэг бас тэднээр хөнөөгдсөн буюу, мөн би өөрийн хүмүүсийн устгалын энэхүү гунигт түүхийг бичихээр бүр ганцаар амьд үлдсэн бөлгөө. Гэвч болгоогтун, тэд үгүй болсон, мөн би эцгийнхээ зарлигийг биелүүлнэ. Мөн тэд намайг хөнөөх эсэхийг би үл мэднэ.
- 4 Тиймийн тул би уг цэдгүүдийг бичиж мөн газарт нуух болно; мөн миний хааш явах нь хамаагүй.
- 5 Болгоогтун, миний эцэг энэ цэдгийг бүтээж, мөн тэрбээр үүний учир шалтгааныг бичсэн болой. Мөн болгоогтун, хэрэв надад уг ялтсууд дээр зай байсан аваас би үүнийг түүнчлэн бичих байв, гэвч надад байхгүй; мөн би ганцаараа учир, надад хүдэр үгүй. Миний эцэг, мөн миний бүх төрөл садан тулалдаанд хөнөөгдсөн, мөн би найз нөхөдгүй мөн явах газаргүй боллоо; мөн намайг хэр удаан амьдарч болно хэмээн Их Эзэн зөвшөөрөхийг би мэдэхгүй.
- 6 Болгоогтун, бидний Их Эзэн мөн Аврагчийн ирэлтээс хойш дөрвөн зуун жил улиран оджээ.
- 7 Мөн болгоогтун, леменчүүд миний хүмүүс, нифайчуудыг, хотоос хотод мөн газраас газарт, бүр тэднийг үгүй болтол нь мөрдөв; мөн тэдний уналт агуу байв; тийм ээ, миний хүмүүс, нифайчуудын устгал агуу хийгээд гайхмаар байлаа.
- 8 Мөн болгоогтун, үүнийг үйлдсэн нь Их Эзэний мутар юм. Мөн түүнчлэн болгоогтун, леменчүүд нэг нэгэнтэйгээ дайнд оржээ; мөн энэ нутгийн бүх гадаргуу үргэлжийн аллага хийгээд цус урсгалтын талбар болов; мөн дайны төгсгөлийг хэн ч үл мэднэ.
- 9 Мөн эдүгээ, болгоогтун, тэдний талаар би илүүт үл дурдана, учир нь уг нутгийн гадаргуу дээр леменчүүд мөн дээрэмчдээс өөр орших хэн ч үгүй бөлгөө.

## Mormon 8

Behold I, Moroni, do finish the record of my father, Mormon. Behold, I have but few things to write, which things I have been commanded by my father.

And now it came to pass that after the great and tremendous battle at Cumorah, behold, the Nephites who had escaped into the country southward were hunted by the Lamanites, until they were all destroyed.

And my father also was killed by them, and I even remain alone to write the sad tale of the destruction of my people. But behold, they are gone, and I fulfil the commandment of my father. And whether they will slay me, I know not.

Therefore I will write and hide up the records in the earth; and whither I go it mattereth not.

Behold, my father hath made this record, and he hath written the intent thereof. And behold, I would write it also if I had room upon the plates, but I have not; and ore I have none, for I am alone. My father hath been slain in battle, and all my kinsfolk, and I have not friends nor whither to go; and how long the Lord will suffer that I may live I know not.

Behold, four hundred years have passed away since the coming of our Lord and Savior.

And behold, the Lamanites have hunted my people, the Nephites, down from city to city and from place to place, even until they are no more; and great has been their fall; yea, great and marvelous is the destruction of my people, the Nephites.

And behold, it is the hand of the Lord which hath done it. And behold also, the Lamanites are at war one with another; and the whole face of this land is one continual round of murder and bloodshed; and no one knoweth the end of the war.

And now, behold, I say no more concerning them, for there are none save it be the Lamanites and robbers that do exist upon the face of the land.

10 Мөн Их Эзэн тэднийг хүмүүстэй үлдэхийг эс зөвшөөрсөн аж, хүмүүсийн ёс бус нь тийм агуу болтол уг нутагт үлдсэн ажгуу, Есүсийн шавь нараас бусад нь бол үнэн Бурханыг мэдэх нэгэн ч үгүй; мөн тэднийг уг нутгийн гадаргуу дээр буй эсэхийг нэг ч хүмүүн эс мэдэх бөлгөө.

11 Гэвч болгоогтун, миний эцэг мөн би тэднийг харсан, мөн тэд бидэнд тохинуулсан болой.

12 Мөн энэ цэдгийг хүлээн авсан, мөн үүнд буй төгс бусаас болж үүнийг үл буруушаах хэн боловч, мөнхүү тэр нь эдгээрээс илүү агуу зүйлсийг мэдэх болно. Болгоогтун, би бол Моронай; мөн боломжтой байсан бол, би бүх зүйлсийг та нарт мэдүүлэхсэн.

13 Болгоогтун, энэ хүмүүсийн талаар ярихаа төгсгөл болгоё би. Би бол Мормоны хүү, мөн миний эцэг Нифайн удам байсан болой.

14 Мөн би бол энэ цэдгийг Их Эзэний төлөө нуух мөнхүү тэр буюу; Их Эзэний зарлигийн улмаас, үүний ялтсууд үнэгүй юм. Учир нь эд хөрөнгө олохын тулд үүнийг хэн ч эс эзэмших болно хэмээн тэрбээр үнэнээр хэлдэг бөлгөө; гэвч үүний цэдэг агуу үнэтэй юм; мөн үүнийг гэрэлд авчрах, түүнийг Их Эзэн адислах болно.

15 Учир нь Бурханаас өгөгдсөнөөр бус аваас үүнийг гэрэлд авчрах хүчийг хэн ч агуулж чадах нь үгүй; учир нь энэ нь түүний алдар суугийн, эсвээс эртний мөн тархаад удсан Их Эзэний гэрээт хүмүүсийн аз жаргалын тулд бүхнээ зориулах учиртай хэмээн Бурхан хүсэх ажгуу.

16 Мөн энэ зүйлийг гэрэлд авчрах тэр нь адислагдах болно; учир нь энэ нь Бурханы үгийн дагуу харанхуйгаас гэрэлдавчрагдах болно; тийм ээ, энэ нь газраас гаргагдан авчрагдаж, мөн энэ нь харанхуйгаас гэрэлтэж, мөн хүмүүсийн мэдлэгт ирэх болно; мөн энэ нь Бурханы хүчээр үйлдэгдэх болно.

17 Мөн хэрэв алдаанууд байх аваас тэдгээр нь хүмүүний алдаанууд бөлгөө. Гэвч болгоогтун, бид ямар ч алдааг эс мэднэ; гэсэн хэдий ч Бурхан бүх зүйлийг мэддэг; тиймийн тул, буруушаах, тэрбээр тамын галын аюулд орох болуузай хэмээн сэрэмжлэг.

18 Мөн: Надад үзүүлэгтүн, эсвээс та цохигдоно хэмээн хэлэх тэр нь—тэрбээр Их Эзэнээр хориглогдсон түүнийг зарлиглах болуузай хэмээн сэрэмжлэг.

And there are none that do know the true God save it be the disciples of Jesus, who did tarry in the land until the wickedness of the people was so great that the Lord would not suffer them to remain with the people; and whether they be upon the face of the land no man knoweth.

But behold, my father and I have seen them, and they have ministered unto us.

And whoso receiveth this record, and shall not condemn it because of the imperfections which are in it, the same shall know of greater things than these. Behold, I am Moroni; and were it possible, I would make all things known unto you.

Behold, I make an end of speaking concerning this people. I am the son of Mormon, and my father was a descendant of Nephi.

And I am the same who hideth up this record unto the Lord; the plates thereof are of no worth, because of the commandment of the Lord. For he truly saith that no one shall have them to get gain; but the record thereof is of great worth; and whoso shall bring it to light, him will the Lord bless.

For none can have power to bring it to light save it be given him of God; for God wills that it shall be done with an eye single to his glory, or the welfare of the ancient and long dispersed covenant people of the Lord.

And blessed be he that shall bring this thing to light; for it shall be brought out of darkness unto light, according to the word of God; yea, it shall be brought out of the earth, and it shall shine forth out of darkness, and come unto the knowledge of the people; and it shall be done by the power of God.

And if there be faults they be the faults of a man. But behold, we know no fault; nevertheless God knoweth all things; therefore, he that condemneth, let him be aware lest he shall be in danger of hell fire.

And he that saith: Show unto me, or ye shall be smitten—let him beware lest he commandeth that which is forbidden of the Lord.

- 19 Учир нь болгоогтун, өнгөцхөн шүүх мөнхүү тэр, хариуд нь өнгөцөөр шүүгдэх болно; учир нь түүний ажлуудын дагуу л түүний хөлс бодогдоно; тиймийн тул, цохих тэр, хариуд нь Их Эзэнээр цохигдох болно.
- 20 Судрын хэлж буйг болгоогтун—хүмүүн цохих учиргүй, бас тэрбээр шүүх ч ёсгүй; учир нь шүүлт бол минийх, мөн өшөө авалт түүнчлэн минийх, мөн би хариу төлнө хэмээн Их Эзэн хэлдэг.
- 21 Мөн Их Эзэний ажлын эсрэг, мөн Израилын угсаа болох Их Эзэний гэрээт хүмүүсийн эсрэг хилэгнэл хийгээд хэрүүл маргааныг ярьдаг, мөн: Бид Их Эзэний ажлыг устгана, мөн Их Эзэн Израилын угсаатай хийсэн гэрээгээ санадаггүй хэмээн хэлдэг тэрээр—мөнхүү тэр нь цавчигдаж мөн галд хаягдах аюулд буй;
- 22 Учир нь Их Эзэний мөнхийн зорилгууд, түүний бүх амлалтууд биелэгдэх хүртэл үргэлжилсээр байх болно.
- 23 Исаиагийн бошиглолуудыг судал. Болгоогтун, би тэдгээрийг бичиж үл чадна. Тийм ээ, болгоогтун, би та нарт хэлнэ, миний өмнө одсон, энэ нутгийг эзэмшиж асан тэдгээр гэгээнтнүүд залбиран гуйх болно, тийм ээ, бүр шорооноос тэд Их Эзэнд хандан залбиран гуйх болно; мөн Их Эзэн амьдын адил тэрбээр тэдэнтэй байгуулсан гэрээгээ санах болно.
- 24 Мөн тэрбээр тэдний залбирлуудыг, тэдгээр нь тэдний ахан дүүсийн төлөө байсныг мэддэг. Мөн тэрбээр тэдний итгэлийг мэддэг, учир нь түүний нэрээр тэд уулыг зайлуулж чадсан юм; мөн түүний нэрээр тэд газар дэлхийг чичиргэж чадсан юм; мөн түүний үгийн хүчээр тэд шоронгуудыг газарт нурах болгосон билээ; тийм ээ, бүр галт зуух ч, бас зэрлэг араатнууд ч, хорт могойнууд ч тэднийг гэмтээж чадаагүй юм.
- 25 Мөн болгоогтун, тэдний залбирлууд түүнчлэн эдгээр зүйлсийг авчрахыг нь Их Эзэн зөвшөөрөх түүний төлөө байсан юм.

For behold, the same that judgeth rashly shall be judged rashly again; for according to his works shall his wages be; therefore, he that smiteth shall be smitten again, of the Lord.

Behold what the scripture says—man shall not smite, neither shall he judge; for judgment is mine, saith the Lord, and vengeance is mine also, and I will repay.

And he that shall breathe out wrath and strifes against the work of the Lord, and against the covenant people of the Lord who are the house of Israel, and shall say: We will destroy the work of the Lord, and the Lord will not remember his covenant which he hath made unto the house of Israel—the same is in danger to be hewn down and cast into the fire;

For the eternal purposes of the Lord shall roll on, until all his promises shall be fulfilled.

Search the prophecies of Isaiah. Behold, I cannot write them. Yea, behold I say unto you, that those saints who have gone before me, who have possessed this land, shall cry, yea, even from the dust will they cry unto the Lord; and as the Lord liveth he will remember the covenant which he hath made with them.

And he knoweth their prayers, that they were in behalf of their brethren. And he knoweth their faith, for in his name could they remove mountains; and in his name could they cause the earth to shake; and by the power of his word did they cause prisons to tumble to the earth; yea, even the fiery furnace could not harm them, neither wild beasts nor poisonous serpents, because of the power of his word.

And behold, their prayers were also in behalf of him that the Lord should suffer to bring these things forth.

- 26 Мөн тэд үл ирнэ хэмээн хэн ч хэлэх хэрэггүй, учир нь тэд гарцаагүй ирэх болно, учир нь Их Эзэн үүнийг хэлсэн билээ; учир нь тэд газраас Их Эзэний мутраар гарч ирэх болно, мөн хэн ч үүнийг зогсоож чадахгүй; мөн гайхамшгууд зогссон хэмээн хэлэгдэх тэр өдөр энэ нь ирэх буюу; мөн энэ нь бүр хэн нэгэн нас барагсдын дундаас ярих лугаа адил ирэх болно.
- 27 Мөн нууц хуйвалдаанууд мөн харанхуйн ажлуудын улмаас, гэгээнтнүүдийн цус Их Эзэнд хандан залбиран гуйх тэр өдөр энэ нь ирнэ.
- 28 Тийм ээ, энэ нь Их Эзэний хүч үгүйсгэгдэж, мөн сүмүүд бузарлагдах болж, мөн тэд зүрх сэтгэлийн бардамналдаа өргөгдөх тэр өдөр; тийм ээ, бүр сүмүүдийн удирдагчид хийгээд багш нар бүр өөрсдийн сүмд харьяалагдах тэдэнд атаархах хүртлээ зүрх сэтгэлийн бардамналдаа хөөрөх тэр өдөр ирнэ.
- 29 Тийм ээ, харь нутгуудад, гал түймэр, мөн догшин шуурга, мөн хөшиглөх утааны талаар сонсогдох тэр өдөр энэ нь ирнэ.
- 30 Мөн түүнчлэн дайнууд, дайны цуурхлууд, мөн хаа сайгүй газар хөдлөлтүүдийн талаар сонсогдох болно.
- 31 Тийм ээ, энэ нь дэлхийн гадаргуу дээр агуу бохирдол байх тэр өдөр ирнэ; аллага, мөн дээрэм, мөн худал үг, мөн заль мэх, мөн садар самуун, мөн бүх төрлийн жигшүүрт хэргүүд байх болно; Үүнийг хий, эсвээс түүнийг хий, мөн Их Эзэн тиймэрхүү нэгнийг эцсийн өдөр дэмжих учир, энэ нь хамаагүй хэмээн хэлэх нь олон байх тэр үед буюу. Гэвч тиймэрхүү нэгэнд халаг, учир нь тэд шаналлын гүн болон алдсын хүлээст буй.
- 32 Тийм ээ, энэ нь: Надад ирэгтүн, мөн мөнгөний-хөө учир та нүглээсээ өршөөгдөх болно хэмээн хэлэх сүмүүд байгуулагдах тэр өдөр ирнэ.
- 33 Ай ёс бус мөн тэрс мөн гөжүүд хүмүүс та нар, яагаад та нар ашиг олохын тулд өөрсдөдөө сүмүүдийг байгуулсан юм бэ? Яагаад та нар өөрсдийн бодгаль дээр ял авчирч болохын учир, Бурханы ариун үгийг хувиргасан бэ? Болгоогтун, Бурханы илчлэлтүүд өөд харагтун, та нар; учир нь болгоогтун, тэр өдөр эдгээр бүх зүйлс биелэгдэх ёстой тэр цаг ирэх болно.

And no one need say they shall not come, for they surely shall, for the Lord hath spoken it; for out of the earth shall they come, by the hand of the Lord, and none can stay it; and it shall come in a day when it shall be said that miracles are done away; and it shall come even as if one should speak from the dead.

And it shall come in a day when the blood of saints shall cry unto the Lord, because of secret combinations and the works of darkness.

Yea, it shall come in a day when the power of God shall be denied, and churches become defiled and be lifted up in the pride of their hearts; yea, even in a day when leaders of churches and teachers shall rise in the pride of their hearts, even to the envying of them who belong to their churches.

Yea, it shall come in a day when there shall be heard of fires, and tempests, and vapors of smoke in foreign lands;

And there shall also be heard of wars, rumors of wars, and earthquakes in divers places.

Yea, it shall come in a day when there shall be great pollutions upon the face of the earth; there shall be murders, and robbing, and lying, and deceivings, and whoredoms, and all manner of abominations; when there shall be many who will say, Do this, or do that, and it mattereth not, for the Lord will uphold such at the last day. But wo unto such, for they are in the gall of bitterness and in the bonds of iniquity.

Yea, it shall come in a day when there shall be churches built up that shall say: Come unto me, and for your money you shall be forgiven of your sins.

O ye wicked and perverse and stiffnecked people, why have ye built up churches unto yourselves to get gain? Why have ye transfigured the holy word of God, that ye might bring damnation upon your souls? Behold, look ye unto the revelations of God; for behold, the time cometh at that day when all these things must be fulfilled.

34 Болгоогтун, та нарын дунд эдгээр зүйлс гарч ирэх тэр өдөр, удахгүй ирэх ёстой түүний талаар Их Эзэн надад агуу хийгээд гайхамшигт зүйлийг үзүүлсэн болой.

35 Болгоогтун, хэдийгээр та нар үгүй ч, та нар өмнө минь буй мэтээр би та нартай ярьж байна. Гэвч болгоогтун, Есүс Христ та нарыг надад үзүүлсэн, мөн би та нарын үйлийг мэднэ.

36 Мөн та нар зүрх сэтгэлийнхээ бардамналд алхдагийг би мэднэ; мөн тансаг өмсгөл өмсөх, атаархах, мөн хэрүүл маргаан, мөн хорсол, мөн хавчлага, мөн бүх төрлийн алдсыг хийх хүртлээ зүрх сэтгэлийнхээ бардамналд өөрсдийгөө өргөдөггүй цөөнөөс өөр хэн ч үгүй; мөн та нарын сүмүүд, тийм ээ, бүр нэг бүрчлэн, та нарын зүрх сэтгэлийн бардамналын улмаас бохирджээ.

37 Учир нь болгоогун, та нар ядуу мөн гачигдалтай, өвчтэй мөн шаналсныг хайрладгаасаа илүүгээр, та нар мөнгөнд мөн өөрсдийн эд хөрөнгө, мөн өөрсдийн тансаг өмсгөл, мөн өөрсдийн сүмийн чимгүүд дээ дуртай.

38 Ай өөрсдийгөө, ялзрах түүний төлөө худалдах бохирдлууд та нар, хоёр нүүртнүүд та нар, багш нар та нар, яагаад та нар Бурханы ариун сүмийг бохирдуулсан бэ? Яагаад та нар Христийн нэрийг өөрсөд дээрээ авахаас ичнэ вэ? Яагаад та нар үргэлжийн аз жаргалын үнэ цэнэ хэзээ ч үл мөхөх зовлонгийнхоос агуу гэж үл бодно вэ—дэлхийн магтаалын улмаас тэр үү

39 Яагаад та нар амьгүй болох түүгээр өөрсдийгөө чимэглэх мөртлөө өлсгөлөн, мөн гачигдалтай, мөн нүцгэн, мөн өвчтэй, мөн шаналсан нь хажуугаар тань өнгөрөн одохыг зөвшөөрч, мөн тэднийг эс анзаарна вэ

40 Тийм ээ, яагаад та нар эд хөрөнгө олохоор нууц жигшүүрт хэргүүдээ сэдэж, мөн бэлэвсэрсэн нь Их Эзэний өмнө гашуудаж, мөн өнчин нь түүнчлэн Их Эзэний өмнө гашуудаж, мөн түүнчлэн тэдний эцгүүдийн мөн нөхрүүдийнх нь цус газраас Их Эзэнд хандан, та нарын толгой дээр өш хонзон авахын тулд гуйн залбирах болгоно вэ

Behold, the Lord hath shown unto me great and marvelous things concerning that which must shortly come, at that day when these things shall come forth among you.

Behold, I speak unto you as if ye were present, and yet ye are not. But behold, Jesus Christ hath shown you unto me, and I know your doing.

And I know that ye do walk in the pride of your hearts; and there are none save a few only who do not lift themselves up in the pride of their hearts, unto the wearing of very fine apparel, unto envying, and strifes, and malice, and persecutions, and all manner of iniquities; and your churches, yea, even every one, have become polluted because of the pride of your hearts.

For behold, ye do love money, and your substance, and your fine apparel, and the adorning of your churches, more than ye love the poor and the needy, the sick and the afflicted.

O ye pollutions, ye hypocrites, ye teachers, who sell yourselves for that which will canker, why have ye polluted the holy church of God? Why are ye ashamed to take upon you the name of Christ? Why do ye not think that greater is the value of an endless happiness than that misery which never dies—because of the praise of the world?

Why do ye adorn yourselves with that which hath no life, and yet suffer the hungry, and the needy, and the naked, and the sick and the afflicted to pass by you, and notice them not?

Yea, why do ye build up your secret abominations to get gain, and cause that widows should mourn before the Lord, and also orphans to mourn before the Lord, and also the blood of their fathers and their husbands to cry unto the Lord from the ground, for vengeance upon your heads?

41 Болгоогун, та нарын дээр өс хонзонгийн илд дайгаастай байна; мөн тэрбээр цашид тэдний залбирлыг тэвчихгүйн учир, тэрбээр гэгээнтнүүдийн цусны өшөөг та нараас авах тэр цаг удахгүй ирнэ.

Behold, the sword of vengeance hangeth over you; and the time soon cometh that he avengeth the blood of the saints upon you, for he will not suffer their cries any longer.

## Мормон 9

- 1 Мөн эдүгээ, би түүнчлэн Христэд итгэдэггүй тэдний талаар ярья.
- 2 Болгоогтун, зочлолын тэр өдөр л та нар итгэх юм уу—болгоогтун, Их Эзэн ирэхэд, тийм ээ, бүр газар дэлхий хуйлмал бичиг мэт хуйлагдаж, мөн бичил хэсгүүд гал халуунд хайлах тэр агуу өдөр, тийм ээ, та Бурханы Хурганы өмнө зогсохоор авчрагдах тэр агуу өдөр—тэгэхэд та нар Бурхан гэж үгүй хэмээн хэлэх үү
- 3 Тэгээд та нар цаашид Христийг үгүйсгэх үү, эсвээс Бурханы Хургыг болгоож чадах уу? Гэмээ ухамсарласнаар та нар түүнтэй цуг орших болно хэмээн та нар бодно уу? Та нарын бодгаль та нар түүний хуулиудыг үргэлж зөрчдөг байсан тэрхүү гэмийнхээ ухамсартайгаар тарчилж байхад, та нар тэрхүү ариун Нэгэнтэй хамт оршихдоо аз жаргалтай байж чадна гэж та нар бодно уу
- 4 Болгоогтун, би та нарт хэлнэ, та нар түүний өмнө бузар булайн ухамсартайгаар, ариун бөгөөд шударга Бурхантай хамт орших нь, та нар тамд яллагдсан бодгалиудтай оршсоноос илүү зовлонтой байх болно.
- 5 Учир нь болгоогтун, та нар Бурханы, мөн түүнчлэн Бурханы алдар суу, мөн Есүс Христийн ариун байдлын өмнө өөрсдийн нүцгэн байдлыг үзэхээр авчрагдах үед, энэ нь та нарын дээр унтаршгүй галын дөл асаах болно.
- 6 Ай тэгвэл үл итгэдэг та нар, та нар Их Эзэнд хандагтун; та нар тэр агуу хийгээд эцсийн өдөр, Хурганы цусаар цэвэрлэгдсэн учир толбогүй, цэвэр ариун, хонгорхон, мөн цагаанаар олдох магадын учир, Есүсийн нэрээр Эцэгт хандан хүчтэйгээр залбиран гуйгтун.
- 7 Мөн түүнчлэн Бурханы илчлэлтүүдийг үгүйсгэж, мөн тэдгээр нь зогссон, илчлэлтүүд, мөн бошиглолууд, мөн бэлгүүд, мөн эдгээх хүч, мөн хэлээр ярих, мөн хэлийг хөрвүүлэх нь үгүй болсон хэмээн хэлэх та нарт би ярина;
- 8 Болгоогтун би та нарт хэлнэ, эдгээр зүйлсийг үгүйсгэдэг тэр нь Христийн сайн мэдээг мэддэггүй; тийм ээ, тэрээр судруудыг уншсан нь үгүй; хэрэв уншсан аваас, тэрээр тэдгээрийг ойлгосон нь үгүй.

## Mormon 9

And now, I speak also concerning those who do not believe in Christ.

Behold, will ye believe in the day of your visitation—behold, when the Lord shall come, yea, even that great day when the earth shall be rolled together as a scroll, and the elements shall melt with fervent heat, yea, in that great day when ye shall be brought to stand before the Lamb of God—then will ye say that there is no God?

Then will ye longer deny the Christ, or can ye behold the Lamb of God? Do ye suppose that ye shall dwell with him under a consciousness of your guilt? Do ye suppose that ye could be happy to dwell with that holy Being, when your souls are racked with a consciousness of guilt that ye have ever abused his laws?

Behold, I say unto you that ye would be more miserable to dwell with a holy and just God, under a consciousness of your filthiness before him, than ye would to dwell with the damned souls in hell.

For behold, when ye shall be brought to see your nakedness before God, and also the glory of God, and the holiness of Jesus Christ, it will kindle a flame of unquenchable fire upon you.

O then ye unbelieving, turn ye unto the Lord; cry mightily unto the Father in the name of Jesus, that perhaps ye may be found spotless, pure, fair, and white, having been cleansed by the blood of the Lamb, at that great and last day.

And again I speak unto you who deny the revelations of God, and say that they are done away, that there are no revelations, nor prophecies, nor gifts, nor healing, nor speaking with tongues, and the interpretation of tongues;

Behold I say unto you, he that denieth these things knoweth not the gospel of Christ; yea, he has not read the scriptures; if so, he does not understand them.

- 9 Учир нь Бурхан өчигдөр, өнөөдөр, мөн үүрд адил, мөн түүнд хувиралт мөн өөрчлөлтийн сүүдэр ч үгүйг бид уншдаг бус уу
- 10 Мөн эдүгээ, хэрэв та нар хувирах мөн өөрчлөлтийн сүүдэртэй тийм бурханыг өөрсдөдөө төсөөлдөг аваас, тэгвэл та нар өөрсдөдөө гайхамшгийн Бурхан биш болох тийм бурханыг төсөөлжээ.
- 11 Гэвч болгоогтун, би та нарт гайхамшгийн Бурханыг, бүр Абрахамын Бурхан, мөн Исаакийн Бурхан, мөн Иаковын Бурханыг үзүүлэх болно; мөн энэ нь тэнгэр ба газрыг, мөн тэдгээрт байх бүх зүйлсийг бүтээсэн тэрхүү Бурхан болой.
- 12 Болгоогтун, тэрбээр Адамыг бүтээсэн, мөн Адамаар хүмүүний уналт ирсэн бөлгөө. Мөн хүмүүний уналтын улмаас Есүс Христ, бүр Эцэг мөн Хүү ирсэн билээ; мөн Есүс Христийн улмаас хүмүүний гэтэлгэл ирсэн юм.
- 13 Мөн Есүс Христээр ирсэн хүмүүний гэтэлгэлийн улмаас, тэд Их Эзэний өмнө буцаан хүргэгдэнэ; тийм ээ, бүхий л хүмүүн гэтэлгэгдэх нь үүгээр ирэх болно, учир нь нэгэн эцэсгүй нойрноос гэтэлгэлийг улируулан тохиолгох тэр амилуулалтыг Христийн үхэл улируулан тохиолгодог, мөн бүрээ дуугарахад бүх хүмүүн Бурханы хүчээр тэрхүү нойрноос сэрээгдэх болно; мөн бага мөн агуу аль аль нь болох тэд гарч ирж, мөн биеийн үхэл болох тэрхүү үхлийн мөнхийн хүлээснээс гэтэлгэгдэн мөн алдуурагдсан учир, бүгдээрээ түүний тавцангийн өмнө зогсох болно.
- 14 Мөн тэгэхэд тэдний дээр Ариун Нэгэний шүүлт ирэх болно; мөн тэгээд бузар нэгэн нь бузраараа үлдэнэ; мөн зөв шударга тэр нь зөв шударгаараа байж, аз жаргалтай тэр нь аз жаргалтайгаараа байж; мөн аз жаргалгүй тэр нь аз жаргалгүй хэвээр байх тэр цаг ирнэ.
- 15 Мөн эдүгээ, Ай гайхамшгийг бүтээж эс чадах нэгэн бурхныг өөрсдөдөө төсөөлсөн та нар бүгд, би та нараас асууя, миний ярьсан эдгээр зүйлүүд бүгд тохиосон уу? Төгсгөл ирчихсэн гэж үү? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй; мөн Бурхан гайхамшгийн Бурхан байхаа болиогүй байна.

For do we not read that God is the same yesterday, today, and forever, and in him there is no variableness neither shadow of changing?

And now, if ye have imagined up unto yourselves a god who doth vary, and in whom there is shadow of changing, then have ye imagined up unto yourselves a god who is not a God of miracles.

But behold, I will show unto you a God of miracles, even the God of Abraham, and the God of Isaac, and the God of Jacob; and it is that same God who created the heavens and the earth, and all things that in them are.

Behold, he created Adam, and by Adam came the fall of man. And because of the fall of man came Jesus Christ, even the Father and the Son; and because of Jesus Christ came the redemption of man.

And because of the redemption of man, which came by Jesus Christ, they are brought back into the presence of the Lord; yea, this is wherein all men are redeemed, because the death of Christ bringeth to pass the resurrection, which bringeth to pass a redemption from an endless sleep, from which sleep all men shall be awakened by the power of God when the trump shall sound; and they shall come forth, both small and great, and all shall stand before his bar, being redeemed and loosed from this eternal band of death, which death is a temporal death.

And then cometh the judgment of the Holy One upon them; and then cometh the time that he that is filthy shall be filthy still; and he that is righteous shall be righteous still; he that is happy shall be happy still; and he that is unhappy shall be unhappy still.

And now, O all ye that have imagined up unto yourselves a god who can do no miracles, I would ask of you, have all these things passed, of which I have spoken? Has the end come yet? Behold I say unto you, Nay; and God has not ceased to be a God of miracles.



- 16 Болгоогтун, Бурханы үйлдсэн зүйлс бидний нүдэнд гайхамшигтай бус гэж үү? Тийм ээ, мөн Бурханы гайхамшигт ажлуудыг хэн ухаарах билээ
- 17 Түүний үгээр тэнгэр болон дэлхий бий болгогдсоныг хэн гайхамшигт биш гэх билээ; мөн түүний үгийн хүчээр дэлхийн тоосноос хүмүүн бүтээгдсэн; мөн гайхамшгууд нь түүний үгийн хүчээр үйлдэгдсэн үү
- 18 Мөн Есүс Христ олон хүчит гайхамшгийг үйлдээгүй хэмээн хэн хэлэх билээ? Мөн төлөөлөгчдийн гараар олон хүчит гайхамшгууд үйлдэгдсэн юм.
- 19 Мөн хэрэв тэр үед гайхамшгууд үйлдэгдсэн аваас, яагаад Бурхан гайхамшгийн Бурхан байхаа больсон атал өөрчлөгдөшгүй Нэгэн хэвээр байх билээ? Мөн болгоогтун, би та нарт хэлнэ, тэр өөрчлөгдөх нь үгүй; хэрэв тэгдэг аваас тэрбээр Бурхан байхаа болино; мөн тэрбээр Бурхан байхаа болих нь үгүй; мөн тэр бол гайхамшгийн Бурхан болой.
- 20 Мөн хүмүүний үрсийн дунд тэрбээр гайхамшгуудыг үйлдэхээ больдгийн шалтгаан нь тэд итгэлгүйдээ бууран доройтож, мөн зөв замаас холдон, мөн тэд найдвал зохих тэр Бурханыг эс мэддэгийн улмаас буюу.
- 21 Болгоогтун, би та нарт хэлнэ, Христэд эргэлзээгүйгээр итгэх хэн боловч, тэрбээр Эцэгээс Христийн нэрээр юуг ч гуйсан тэр нь түүнд өгөгдөх болно; мөн энэ амлалт нь бүгдэд, бүр дэлхийн хязгааруудад ч адил буюу.
- 22 Учир нь болгоогтун, Есүс Христ, Бурханы Хүү, үлдэх учиртай өөрийн шавь нарт, тийм ээ, мөн түүнчлэн өөрийн бүх шавь нарт, цугларсан олонд сонсогдохоор: та нар бүх дэлхийгээр явагтун, мөн хүмүүн бүрт сайн мэдээг номлогтун хэмээн хэлжээ.
- 23 Мөн итгэж мөн баптисм хүртсэн тэр нь аврагдах болно, гэвч итгэдэггүй тэр нь яллагдах болно.
- 24 Мөн эдгээр тэмдгүүд итгэдэг тэднийг дагана—миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулна; тэд шинэ хэлээр ярих болно; тэд могойнуудыг барьж авах болно; мөн тэд үхлийн аюулт юуг ч уусан тэр нь тэднийг гэмтээхгүй; тэд гараа өвчөн дээр тавихад мөн тэд эдгэнэ;

Behold, are not the things that God hath wrought marvelous in our eyes? Yea, and who can comprehend the marvelous works of God?

Who shall say that it was not a miracle that by his word the heaven and the earth should be; and by the power of his word man was created of the dust of the earth; and by the power of his word have miracles been wrought?

And who shall say that Jesus Christ did not do many mighty miracles? And there were many mighty miracles wrought by the hands of the apostles.

And if there were miracles wrought then, why has God ceased to be a God of miracles and yet be an unchangeable Being? And behold, I say unto you he changeth not; if so he would cease to be God; and he ceaseth not to be God, and is a God of miracles.

And the reason why he ceaseth to do miracles among the children of men is because that they dwindle in unbelief, and depart from the right way, and know not the God in whom they should trust.

Behold, I say unto you that whoso believeth in Christ, doubting nothing, whatsoever he shall ask the Father in the name of Christ it shall be granted him; and this promise is unto all, even unto the ends of the earth.

For behold, thus said Jesus Christ, the Son of God, unto his disciples who should tarry, yea, and also to all his disciples, in the hearing of the multitude: Go ye into all the world, and preach the gospel to every creature;

And he that believeth and is baptized shall be saved, but he that believeth not shall be damned;

And these signs shall follow them that believe—in my name shall they cast out devils; they shall speak with new tongues; they shall take up serpents; and if they drink any deadly thing it shall not hurt them; they shall lay hands on the sick and they shall recover;

- 25 Мөн эргэлзээгүйгээр миний нэрэнд итгэдэг хэнд боловч, түүнд, бүр дэлхийн хязгааруудад хүртэл би өөрийн бүх үгийг нотлох болно.
- 26 Мөн эдүгээ, болгоогтун, Их Эзэний ажлын эсрэг хэн зогсож чадах билээ? Түүний хэлснийг хэн үгүйсгэж чадах билээ? Их Эзэний бүхнийг чадагч хүчийн эсрэг хэн босох билээ? Их Эзэний ажлыг хэн үзэн ядах билээ? Христийн хүүхдүүдийг хэн үзэн ядах билээ? Болгоогтун, Их Эзэний ажлыг үзэн ядагч та нар бүгдээр, учир нь та нар гайхширч мөн үрэгдэх болно.
- 27 Ай тэгвэл бүү үзэн яд, мөн бүү гайхшир, харин Их Эзэний үгсийг анхааран сонс, мөн өөрт хэрэгцээтэй ямар ч зүйлийн төлөө Эцэгээс, Есүсийн нэрээр гуй. Бүү эргэлз, харин итгэлтэй бай, мөн эрт цагийнхны адилаар эхэл, мөн бүх зүрх сэтгэлээрээ Их Эзэнд ирэгтүн, мөн түүний өмнө айж мөн сүрдсэнээр авралаа гүйцээгтүн.
- 28 Сорилтынхоо өдрүүдэд ухаалаг бай; бүх цэвэр бусыг өөрсдөөсөө зайлуул; шунал хүслээрээ үүнийг үрж дуусгаж болохын тулд бүү гуй, харин та нар ямар ч уруу таталтанд байр тавилгүй, харин та нар үнэн хийгээд амьд Бурханд үйлчилнэ гэсэн гуйвшгүй шийдмэг байдалтайгаар гуй.
- 29 Зохисгүйгээр баптисм хийлгэхгүй байхаа мэд; зохисгүйгээр Христийн ариун ёслолоос хүртэхгүй байхаа мэд; харин бүх зүйлийг зохистойгоор хийхээ, мөн амьд Бурханы Хүү, Есүс Христийн нэрээр хийхээ мэд; мөн хэрэв та нар үүнийг хийж, мөн эцсээ хүртэл тэвчих аваас, та нар яавч зайлуулагдах учиргүй.
- 30 Болгоогтун, би нас барагсдаас ярьж буй мэтээр би та нарт ярьж байна; учир нь та нар миний үгсийг авна гэдгийг би мэднэ.
- 31 Миний төгс бусын улмаас намайг, бас түүний төгс бусын улмаас эцгийг минь ч, бас түүний өмнө бичсэн тэднийг ч бүү буруушаа; харин та нар бидний байснаас илүү ухаалаг байхад сурч болохын тулд, бидний төгс бусыг та нарт илчилсэнд нь Бурханд талархлаа мэдүүл.

And whosoever shall believe in my name, doubting nothing, unto him will I confirm all my words, even unto the ends of the earth.

And now, behold, who can stand against the works of the Lord? Who can deny his sayings? Who will rise up against the almighty power of the Lord? Who will despise the works of the Lord? Who will despise the children of Christ? Behold, all ye who are despisers of the works of the Lord, for ye shall wonder and perish.

O then despise not, and wonder not, but hearken unto the words of the Lord, and ask the Father in the name of Jesus for what things soever ye shall stand in need. Doubt not, but be believing, and begin as in times of old, and come unto the Lord with all your heart, and work out your own salvation with fear and trembling before him.

Be wise in the days of your probation; strip yourselves of all uncleanness; ask not, that ye may consume it on your lusts, but ask with a firmness unshaken, that ye will yield to no temptation, but that ye will serve the true and living God.

See that ye are not baptized unworthily; see that ye partake not of the sacrament of Christ unworthily; but see that ye do all things in worthiness, and do it in the name of Jesus Christ, the Son of the living God; and if ye do this, and endure to the end, ye will in nowise be cast out.

Behold, I speak unto you as though I spake from the dead; for I know that ye shall have my words.

Condemn me not because of mine imperfection, neither my father, because of his imperfection, neither them who have written before him; but rather give thanks unto God that he hath made manifest unto you our imperfections, that ye may learn to be more wise than we have been.

- 32 Мөн эдүгээ, болгоогтун, энэ цэдгийг, бидний ярианы маягийн дагуу, биднээр доош дамжигдан мөн өөрчлөгдсөн, шинэчлэгдсэн египет хэмээн бидний дунд нэрлэгддэг үсгүүдээр бид өөрсдийн мэдлэгийн дагуу бичсэн болой.
- 33 Мөн хэрэв бидний ялтсууд хангалттай том байсан аваас бид еврей хэл дээр бичих байсан; гэвч еврей хэл түүнчлэн биднээр шинэчлэгдсэн бөлгөө; мөн хэрэв бид еврей хэл дээр бичиж чадсан бол, болгоогтун, бидний цэдэгт та нар төгс бус юуг ч эс олох байсан.
- 34 Гэвч Их Эзэн бидний бичсэн зүйлсийг, мөн түүнчлэн өөр ямар ч хүмүүс бидний хэлийг эс мэднэ гэдгийг мэднэ; мөн бидний хэлийг өөр ямар ч хүмүүс эс мэдэхийн учир, тиймийн учир үүний хөрвүүлгийн төлөө тэрбээр нэгэн хэрэгслийг бэлтгэсэн болой.
- 35 Мөн итгэлгүйдээ бууран доройтсон ах дүүсийнхээ цусыг өмсгөлөөсөө арилгахын тулд эдгээр зүйлүүд бичигдсэн бөлгөө.
- 36 Мөн болгоогтун, ахан дүүсийнхээ талаар бидний хүссэн эдгээр зүйлс, тийм ээ, учир нь, Христийн мэдлэг дэхь тэдний сэргээлт уг нутагт оршин сууж асан бүх гэгээнтнүүдийн залбирлуудын дагуу буюу.
- 37 Мөн тэдний итгэлийн дагуу залбирлууд нь хариулагдаж болохыг Их Эзэн Есүс Христ зөвшөөрөх болтугай; мөн Бурхан Эцэг Израилын угсаатай хийсэн гэрээгээ санах болтугай; мөн тэрбээр тэднийг Есүс Христийн нэрэнд итгэх итгэлээр нь дамжуулан үүрд адислах болтугай. Амен.

And now, behold, we have written this record according to our knowledge, in the characters which are called among us the reformed Egyptian, being handed down and altered by us, according to our manner of speech.

And if our plates had been sufficiently large we should have written in Hebrew; but the Hebrew hath been altered by us also; and if we could have written in Hebrew, behold, ye would have had no imperfection in our record.

But the Lord knoweth the things which we have written, and also that none other people knoweth our language; and because that none other people knoweth our language, therefore he hath prepared means for the interpretation thereof.

And these things are written that we may rid our garments of the blood of our brethren, who have dwindled in unbelief.

And behold, these things which we have desired concerning our brethren, yea, even their restoration to the knowledge of Christ, are according to the prayers of all the saints who have dwelt in the land.

And may the Lord Jesus Christ grant that their prayers may be answered according to their faith; and may God the Father remember the covenant which he hath made with the house of Israel; and may he bless them forever, through faith on the name of Jesus Christ. Amen.

# ИФЕРИЙН НОМ

*Мозая хааны өдрүүдэд, Лимхайн хүмүүсээр олдсон хорин дөрвөн ялтсаас авагдсан жаредчуудын цэдэг оривой.*

## Ифер 1

- 1 Мөн одоо би, Моронай, хойд зүгийн энэ нутгийн гадаргуу дээр Их Эзэний мутраар устгагдсан эртний оршин суугчдын шастирыг өгөхөө үргэлжлүүлье.
- 2 Мөн би өөрийн шастирыг Лимхайн хүмүүсээр олдсон, Иферийн Ном хэмээн нэрлэгдэх хорин дөрвөн ялтсаас авах болно.
- 3 Мөн дэлхийн, мөн түүнчлэн Адамын үүслийн талаар өгүүлэх мөнхүү тэр цагаас агуу цамхгийг хүртэлх шастир, мөн тэр цагийг хүртэл хүмүүний үрсийн дунд тохиосон бүх зүйлүүд бүхий энэхүү цэдгийн эхний хэсэг нь иудейчүүдийн дунд байсаар ирсэн хэмээн би таамаглах буюу—
- 4 Тиймийн тул Адамын өдрүүдээс тэр цагийг хүртэл тохиосон тэдгээр зүйлийг би үл бичнэ; харин тэдгээр нь ялтсууд дээр буй; мөн тэдгээрийг олсон хэн боловч, чухамхүү тэр нь бүрэн шастирыг авч болох хүчтэй болно.
- 5 Гэвч болгоогтун, би бүхэл шастирыг эс өгнө, харин цамхгаас тэд устгагдах хүртэл шастирын хэсгийг би өгье.
- 6 Мөн ийм маягаар би шастирыг өгье. Энэ цэдгийг бичсэн тэр нь Ифер байсан ажгуу, мөн тэрээр Корианторын удам байв.
- 7 Кориантор нь Мороны хүү байв.
- 8 Мөн Морон нь Ифемийн хүү байв.
- 9 Мөн Ифем нь Ахагийн хүү байв.
- 10 Мөн Аха нь Сетийн хүү байв.
- 11 Мөн Сет нь Шиблоны хүү байв.
- 12 Мөн Шиблон нь Комын хүү байв.
- 13 Мөн Ком нь Кориантумын хүү байв.
- 14 Мөн Кориантум нь Амнигаддагийн хүү байв.
- 15 Мөн Амнигадда нь Аароны хүү байв.
- 16 Мөн Аарон нь Хирфомын хүү асан Хетийн удам байв.

# The Book of Ether

*The record of the Jaredites, taken from the twenty-four plates found by the people of Limhi in the days of King Mosiah.*

## Ether 1

And now I, Moroni, proceed to give an account of those ancient inhabitants who were destroyed by the hand of the Lord upon the face of this north country.

And I take mine account from the twenty and four plates which were found by the people of Limhi, which is called the Book of Ether.

And as I suppose that the first part of this record, which speaks concerning the creation of the world, and also of Adam, and an account from that time even to the great tower, and whatsoever things transpired among the children of men until that time, is had among the Jews—

Therefore I do not write those things which transpired from the days of Adam until that time; but they are had upon the plates; and whoso findeth them, the same will have power that he may get the full account.

But behold, I give not the full account, but a part of the account I give, from the tower down until they were destroyed.

And on this wise do I give the account. He that wrote this record was Ether, and he was a descendant of Coriantor.

Coriantor was the son of Moron.

And Moron was the son of Ethem.

And Ethem was the son of Ahah.

And Ahah was the son of Seth.

And Seth was the son of Shiblon.

And Shiblon was the son of Com.

And Com was the son of Coriantum.

And Coriantum was the son of Amnigaddah.

And Amnigaddah was the son of Aaron.

And Aaron was a descendant of Heth, who was the son of Hearthom.

17 Мөн Хирфом нь Либийн хүү байв.  
18 Мөн Либ нь Кишийн хүү байв.  
19 Мөн Киш нь Коромын хүү байв.  
20 Мөн Кором нь Ливайн хүү байв.  
21 Мөн Ливай нь Кимийн хүү байв.  
22 Мөн Ким нь Мориантоны хүү байв.  
23 Мөн Мориантон нь Риплакишийн удам байв.  
24 Мөн Риплакиш нь Шезийн хүү байв.  
25 Мөн Шез нь Хетийн хүү байв.  
26 Мөн Хет нь Комын хүү байв.  
27 Мөн Ком нь Кориантумын хүү байв.  
28 Мөн Кориантум нь Имерийн хүү байв.  
29 Мөн Имер нь Омерын хүү байв.  
30 Мөн Омер нь Шулегийн хүү байв.  
31 Мөн Шуле нь Кибийн хүү байв.  
32 Мөн Киб нь Жаредын хүү асан, Ораихагийн хүү байв;  
33 Хүмүүсийн хэлийг будлиулсан, мөн тэд дэлхийн бүх гадаргуу дээр тараагдах болно хэмээн Их Эзэн хилэгнэлдээ тангарагласан тэр цагт, өөрийн ах болон тэдний гэр бүлтэй, бусад зарим болон тэдний гэр бүлүүдийн хамтаар тэрхүү Жаред сайхь агуу цамхгаас одсон ажээ; мөн Их Эзэний үгийн дагуу хүмүүс тараагдав.  
34 Мөн Жаредын ах том биетэй мөн хүчирхэг эр, мөн Их Эзэний өндөр их ээл хишгийг хүртсэн эр болохын учир, түүний дүү, Жаред, түүнд хандаж хэлсэн нь: Тэрээр биднийг бусниулснаас бид өөрсдийн үгийг үл ойлголцоход хүрэхгүйн тулд Их Эзэнээс залбиран гуй.  
35 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнээс залбиран гуйсан бөгөөд, мөн Их Эзэн Жаредыг өрөвдөн хайрлав; тиймийн тул тэр Жаредын хэлийг бусниулсангүй; мөн Жаред мөн түүний ах бусниулагдсангүй.  
36 Тэгээд Жаред ахдаа хэлсэн нь: Тэрээр уур хилэнгээ бидний найзууд болох тэднээс холдуулснаар тэдний хэлийг үл бусниулахын тулд Их Эзэнээс дахин залбиран гуйгтун.

And Hearthom was the son of Lib.  
And Lib was the son of Kish.  
And Kish was the son of Corom.  
And Corom was the son of Levi.  
And Levi was the son of Kim.  
And Kim was the son of Morianton.  
And Morianton was a descendant of Riplakish.  
And Riplakish was the son of Shez.  
And Shez was the son of Heth.  
And Heth was the son of Com.  
And Com was the son of Coriantum.  
And Coriantum was the son of Emer.  
And Emer was the son of Omer.  
And Omer was the son of Shule.  
And Shule was the son of Kib.  
And Kib was the son of Orihah, who was the son of Jared;

Which Jared came forth with his brother and their families, with some others and their families, from the great tower, at the time the Lord confounded the language of the people, and swore in his wrath that they should be scattered upon all the face of the earth; and according to the word of the Lord the people were scattered.

And the brother of Jared being a large and mighty man, and a man highly favored of the Lord, Jared, his brother, said unto him: Cry unto the Lord, that he will not confound us that we may not understand our words.

And it came to pass that the brother of Jared did cry unto the Lord, and the Lord had compassion upon Jared; therefore he did not confound the language of Jared; and Jared and his brother were not confounded.

Then Jared said unto his brother: Cry again unto the Lord, and it may be that he will turn away his anger from them who are our friends, that he confound not their language.

37 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнээс залбиран гуйв, мөн түүнчлэн Их Эзэн тэдний найзуудыг мөн тэдний гэр бүлүүдийг өрөвдөн хайрласнаас, тэд үл бусниулагдав.

38 Мөнхүү улиран тохиох дор Жаред ахтайгаа дахин ярьж, хэлрүүн: Явж мөн тэрээр биднийг энэ нутгаас хөөн гаргах эсэхийг Их Эзэнээс лавлагтун, мөн хэрэв тэрээр биднийг энэ нутгаас хөөн гаргах аваас, бид хааш одохыг түүнээс залбиран асуугтун. Мөн бүх дэлхийд бүгдээс дээгүүр сонгомол болох тэрхүү нутагт Их Эзэн биднийг хүргэх эсэхийг хэн мэдэх билээ? Мөн хэрэв тийм байх аваас, бид түүнийг өөрсдийн өв болгон хүлээн авч болохын тулд, Их Эзэнд итгэлтэй байцгаая.

39 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнд хандан Жаредын амаар хэлэгдсэн тэдгээрийн дагуу залбиран асуусан аж.

40 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Жаредын ахыг сонсон, мөн түүнийг өрөвдөн хайрлаж, мөн түүнд хэлсэн нь:

41 Явж мөн өөрийн бүх л төрлийн эр ч бай эм ч бай мал сүргээ; мөн бас бүх л төрлийн дэлхийн үрээс; мөн гэр бүлийнхнээ; мөн бас өөрийн дүү Жаред болон түүний гэр бүлийг; мөн бас найзуудаа мөн тэдний гэр бүлүүдийг мөн Жаредын найзууд болон тэдний гэр бүлүүдийг цуглуулагтун.

42 Мөн үүнийг хийж дууссаныхаа дараа тэдний тэргүүнд хойд зүгт орших хөндий тийш уруудан явагтун. Мөн тэнд би чамтай уулзах болно, мөн би чиний өмнө дэлхийн бүх газруудаас дээгүүрт сонгомол тэр нутаг тийш явах болно.

43 Мөн тэнд би чамайг болон чиний үр удмыг адислах болно, мөн чиний үр удмаас, мөн чиний дүүгийн үр удмаас, мөн чамтай цуг явах тэднээс, агуу үндэстнийг би өөртөө өсгөнө. Мөн дэлхийн бүх л гадаргуу дээр чиний үр удмаас би өөртөө өсгөн авах тэр үндэстнээс илүү агуу нь үгүй болой. Мөн чи надад хандан ийм удаан хугацаагаар залбиран гуйсны учир би чамд тийн үйлдэх буюу.

And it came to pass that the brother of Jared did cry unto the Lord, and the Lord had compassion upon their friends and their families also, that they were not confounded.

And it came to pass that Jared spake again unto his brother, saying: Go and inquire of the Lord whether he will drive us out of the land, and if he will drive us out of the land, cry unto him whither we shall go. And who knoweth but the Lord will carry us forth into a land which is choice above all the earth? And if it so be, let us be faithful unto the Lord, that we may receive it for our inheritance.

And it came to pass that the brother of Jared did cry unto the Lord according to that which had been spoken by the mouth of Jared.

And it came to pass that the Lord did hear the brother of Jared, and had compassion upon him, and said unto him:

Go to and gather together thy flocks, both male and female, of every kind; and also of the seed of the earth of every kind; and thy families; and also Jared thy brother and his family; and also thy friends and their families, and the friends of Jared and their families.

And when thou hast done this thou shalt go at the head of them down into the valley which is northward. And there will I meet thee, and I will go before thee into a land which is choice above all the lands of the earth.

And there will I bless thee and thy seed, and raise up unto me of thy seed, and of the seed of thy brother, and they who shall go with thee, a great nation. And there shall be none greater than the nation which I will raise up unto me of thy seed, upon all the face of the earth. And thus I will do unto thee because this long time ye have cried unto me.

## Ифер 2

- 1 Мөнхүү улиран тохиох дор Жаред мөн түүний ах, мөн тэдний гэр бүлүүд, мөн түүнчлэн Жаредын найзууд, мөн түүний ах мөн тэдний гэр бүлүүд, бүх л төрлийн эр ч бай эм ч бай, цуглуулсан мал сүрэгтэйгээ хойд зүгт орших хөндий тийш (мөн хөндийн нэр нь Нимрод хэмээн хүчит анчны нэрээр нэрлэгдсэн байв) уруудан явав.
- 2 Мөн түүнчлэн тэд тор тавин мөн агаарын жигүүртнийг барив, мөн усны загасыг өөрсөдтэйгөө авч явах тэр савыг тэд түүнчлэн бэлтгэв.
- 3 Мөн тэд түүнчлэн балт зөгий хэмээгдэн хөрвүүлэгдэх дезертийг өөрсөдтэйгээ авч явав, мөн тэд тийн дэлхийн гадаргуу дээр байсан бүл зөгийнүүдийг, мөн бүхий зүйлсээс, бүх л төрлийн үрийг өөрсөдтэйгээ авч явав.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэд уруудан Нимродын хөндийд ирэхэд Их Эзэн бууж ирээд мөн Жаредын ахтай ярив; мөн тэрээр үүлэн дунд байж, мөн Жаредын ах түүнийг үл харсан аж.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн аглаг буйд тийш, тийм ээ, хэзээ ч хүн хүрээгүй тэр хэсэг тийш явахыг тэдэнд зарлиглав. Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн тэдний өмнө яван, мөн тэр үүлэн дунд зогсохдоо тэдэнтэй ярьж, мөн тэдний хааш аялахыг зааварлав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэд аглаг буйдаар аялж, мөн хөлгүүдийг босгож, Их Эзэний мутраар үргэлжид удирдуулан, түүгээр тэд их усыг гатлав.
- 7 Мөн Их Эзэн тэдэнд тэнгисийн цаадах аглаг буйдад зогсохыг нь үл зөвшөөрөн, харин тэрээр тэднийг Их Эзэн Бурханы зөв шударга хүмүүст хадгалсан бүх бусад нутгуудаас сонгомол болох, бүр амлалтын нутагт хүртэл явахыг хүсэв.
- 8 Мөн тэр цагаас эхлэн мөн үүрд энэхүү амлалтын нутгийг эзэмших хэн боловч, өөрт нь, үнэн бөгөөд цорын ганц Бурханд үйлчлэх учиртай, эс бөгөөс түүний хилэн тэр чигээрээ тэдний дээр ирэхэд тэд арчигдах болно хэмээн тэрээр Жаредын ахад уур хилэндээ тангарагласан байв.

## Ether 2

And it came to pass that Jared and his brother, and their families, and also the friends of Jared and his brother and their families, went down into the valley which was northward, (and the name of the valley was Nimrod, being called after the mighty hunter) with their flocks which they had gathered together, male and female, of every kind.

And they did also lay snares and catch fowls of the air; and they did also prepare a vessel, in which they did carry with them the fish of the waters.

And they did also carry with them deseret, which, by interpretation, is a honey bee; and thus they did carry with them swarms of bees, and all manner of that which was upon the face of the land, seeds of every kind.

And it came to pass that when they had come down into the valley of Nimrod the Lord came down and talked with the brother of Jared; and he was in a cloud, and the brother of Jared saw him not.

And it came to pass that the Lord commanded them that they should go forth into the wilderness, yea, into that quarter where there never had man been. And it came to pass that the Lord did go before them, and did talk with them as he stood in a cloud, and gave directions whither they should travel.

And it came to pass that they did travel in the wilderness, and did build barges, in which they did cross many waters, being directed continually by the hand of the Lord.

And the Lord would not suffer that they should stop beyond the sea in the wilderness, but he would that they should come forth even unto the land of promise, which was choice above all other lands, which the Lord God had preserved for a righteous people.

And he had sworn in his wrath unto the brother of Jared, that whoso should possess this land of promise, from that time henceforth and forever, should serve him, the true and only God, or they should be swept off when the fulness of his wrath should come upon them.

- 9 Мөн эдүгээ, энэ нутгийн талаар Бурханы тогтоолыг, энэ нь амлалтын нутаг гэдгийг бид болгоож чадна; мөн үүнийг эзэмших ямар ч үндэстэн Бурханд үйлчлэх болно, эс бөгөөс түүний хилэн тэр чигээрээ тэдний дээр ирэхэд тэд арчигдах болно. Мөн тэд алдастаа бүрнээ боловсорсон үед түүний хилэн тэр чигээрээ тэдний дээр ирнэ.
- 10 Учир нь болгоогтун, энэ бол бусад бүх нутгуудаас сонгомол тэрхүү нутаг болой; иймийн тул үүнийг эзэмших тэр нь Бурханд үйлчлэх буюу, эс бөгөөс арчигдах болно; учир нь энэ бол Бурханы үүрдийн тогтоол юм. Мөн уг нутгийн үрсийн дунд алдас бүрэн дүүрэн болтол, тэд арчигдах нь үгүй.
- 11 Мөн энэ нь та нарт ирнэ, Ай харийнхан та нар, та нар Бурханы тогтоолуудыг мэдэж болохын тулд—та нар наманчилж, мөн бүрэн дүүрэн нь ирэх хүртэл алдсаа үргэлжлүүлэхгүй байж болохын учир, уг нутгийг өвлөгчид өмнө нь үйлдсэний адилаар Бурханы уур хилэнгийн бүрэн дүүрнийг та нар өөрсөд дээрээ авчрахгүй байж болохын тулд мөн энэ нь та нарт ирнэ.
- 12 Болгоогтун, энэ бол сонгомол нутаг, мөн үүнийг эзэмшигч ямарваа үндэстэн, хэрэв тэд уг нутгийн Бурхан, бидний бичсэн зүйлсээр үзүүлэгдсэн Есүс Христэд л зөвхөн үйлчлэх аваас, дарангуйллаас, мөн боолчлолоос, мөн тэнгэрийн доорх бусад бүх үндэстнээс ангид байх болно.
- 13 Мөн эдүгээ би цэдгээ үргэлжжүүлье; учир нь болгоогтун, улиран тохиох дор Их Эзэн Жаред мөн түүний ахан дүүсийг газрыг хуваагч тэрхүү агуу далайд урагш авчрав. Мөн тэд далайн дэргэд ирээд майхнаа тэд босгов; мөн тэд уг газрын нэрийг Морианкумер гэв; мөн тэд майхнуудад амьдарч байв, далайн эрэг дээр дөрвөн жилийн туршид майхнуудад амьдарсан ажгуу.
- 14 Мөнхүү улиран тохиох дор дөрвөн жилийн шувтарганд Их Эзэн Жаредын ахад дахин ирж, мөн үүлэн дунд зогсоод түүнтэй ярив. Мөн гурван цагийн турш Их Эзэн Жаредын ахтай ярьж, тэрээр Их Эзэний нэрийг дуудахаа эс санасных нь учир түүнийг зэмлэв.

And now, we can behold the decrees of God concerning this land, that it is a land of promise; and whatsoever nation shall possess it shall serve God, or they shall be swept off when the fulness of his wrath shall come upon them. And the fulness of his wrath cometh upon them when they are ripened in iniquity.

For behold, this is a land which is choice above all other lands; wherefore he that doth possess it shall serve God or shall be swept off; for it is the everlasting decree of God. And it is not until the fulness of iniquity among the children of the land, that they are swept off.

And this cometh unto you, O ye Gentiles, that ye may know the decrees of God—that ye may repent, and not continue in your iniquities until the fulness come, that ye may not bring down the fulness of the wrath of God upon you as the inhabitants of the land have hitherto done.

Behold, this is a choice land, and whatsoever nation shall possess it shall be free from bondage, and from captivity, and from all other nations under heaven, if they will but serve the God of the land, who is Jesus Christ, who hath been manifested by the things which we have written.

And now I proceed with my record; for behold, it came to pass that the Lord did bring Jared and his brethren forth even to that great sea which divideth the lands. And as they came to the sea they pitched their tents; and they called the name of the place Moriancumer; and they dwelt in tents, and dwelt in tents upon the seashore for the space of four years.

And it came to pass at the end of four years that the Lord came again unto the brother of Jared, and stood in a cloud and talked with him. And for the space of three hours did the Lord talk with the brother of Jared, and chastened him because he remembered not to call upon the name of the Lord.



15 Мөн Жаредын ах өөрийн хийсэн хилэнцэт үйлээ наманчлав, мөн өөртэйгөө хамт байсан ахан дүүсийнхээ төлөө Их Эзэний нэрийг дуудав. Мөн Их Эзэн түүнд хэлсэн нь: Чамайг болон ахан дүүсийг чинь нүглээс нь өршөөе би; харин та нар цаашид нүгэл үйлдэх ёсгүй, учир нь миний Сүнс хүмүүний төлөө үргэлж зүтгэх нь үгүй гэдгийг та нар санах болно; иймийн тул, хэрэв та нар бүрэн боловсрох хүртлээ нүгэл үйлдэх аваас Их Эзэний дэргэдээс та нар тусгаарлагдах болно. Мөн эдгээр нь би та нарт өвлүүлэн өгөх тэр нутгийн талаарх миний бодол юм; учир нь энэ нь бусад бүх нутгуудаас сонгомол нутаг байх болно.

16 Мөн Их Эзэн хэлрүүн: Явж ажилла, мөн эдүгээгээс өмнө та нар босгож байсан хөлгүүдийнхээ адил хөлгийг босгогтун. Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах, мөн түүнчлэн түүний ахан дүүс ажиллахаар явж, мөн тэд Их Эзэний зааврын дагуу босгож байсныхаа адилаар хөлгүүдийг босгов. Мөн тэдгээр нь жижиг, мөн бүр тэдгээр нь усан дээр жигүүртэн хөнгөхөн байдгийн адилаар усан дээр тийм хөнгөн байв.

17 Мөн тэдгээр нь туйлын нягт байхаар, бүр таваг лугаа адил усыг агуулахуйцаар баригджээ; мөн ёроол нь таваг лугаа адил нягт байв; мөн талууд нь таваг мэт нягт байв; мөн төгсгөлүүд нь дээш өргөгдсөн байв; мөн дээд тал нь таваг мэт нягт байв; мөн урт нь модны уртын адил байв; мөн үүд нь, хаалттай байхдаа, таваг мэт нягт байв.

18 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэнд хандан залбирч, хэлсэн нь: Ай Их Эзэн, таны надад зарлигласан ажлыг би гүйцэлдүүлэв, мөн би таны заасны дагуу хөлгүүдийг бүтээлээ.

19 Мөн болгоогтун, Ай Их Эзэн, тэдэн дотор гэрэл үгүй болой; бид хааш залах вэ? Мөн бид дотор нь буй агаараас өөр амьсгалах зүйл үгүйн учир, түүнчлэн бид үрэгдэх буюу; тиймийн тул бид үрэгдэх болно.

20 Мөн Их Эзэн Жаредын ахад хандан өгүүлсэн нь: Болгоогтун, та нар оройд нь, мөн бас ёроолд нь нүхэлсүгэй; мөн агаар дутагдах үедээ нүхээ нээж мөн агаар оруулах болно. Мөн хэрэв та нар дээр ус орж ирэх аваас, та нар үерт үрэгдэхгүй байж болохын тулд болгоогтун, та нар уг нүхийг бөглөх болно.

And the brother of Jared repented of the evil which he had done, and did call upon the name of the Lord for his brethren who were with him. And the Lord said unto him: I will forgive thee and thy brethren of their sins; but thou shalt not sin any more, for ye shall remember that my Spirit will not always strive with man; wherefore, if ye will sin until ye are fully ripe ye shall be cut off from the presence of the Lord. And these are my thoughts upon the land which I shall give you for your inheritance; for it shall be a land choice above all other lands.

And the Lord said: Go to work and build, after the manner of barges which ye have hitherto built. And it came to pass that the brother of Jared did go to work, and also his brethren, and built barges after the manner which they had built, according to the instructions of the Lord. And they were small, and they were light upon the water, even like unto the lightness of a fowl upon the water.

And they were built after a manner that they were exceedingly tight, even that they would hold water like unto a dish; and the bottom thereof was tight like unto a dish; and the sides thereof were tight like unto a dish; and the ends thereof were peaked; and the top thereof was tight like unto a dish; and the length thereof was the length of a tree; and the door thereof, when it was shut, was tight like unto a dish.

And it came to pass that the brother of Jared cried unto the Lord, saying: O Lord, I have performed the work which thou hast commanded me, and I have made the barges according as thou hast directed me.

And behold, O Lord, in them there is no light; whither shall we steer? And also we shall perish, for in them we cannot breathe, save it is the air which is in them; therefore we shall perish.

And the Lord said unto the brother of Jared: Behold, thou shalt make a hole in the top, and also in the bottom; and when thou shalt suffer for air thou shalt unstop the hole and receive air. And if it be so that the water come in upon thee, behold, ye shall stop the hole, that ye may not perish in the flood.

- 21 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах Их Эзэн зарлигласны дагуу хийсэн бөлгөө.
- 22 Мөн тэрээр Их Эзэнд хандан дахин залбирч, хэлрүүн: Ай Их Эзэн, болгоогтун таны надад зарлиг болсноор би хийв; мөн би өөрийн хүмүүст хөлгүүдийг бэлтгэв, мөн болгоогтун тэдэн дотор гэрэл үгүй байна. Болгоогтун, Ай Их Эзэн, бид энэ их усыг харанхуйд гатлахыг та зөвшөөрнө гэж үү
- 23 Мөн Их Эзэн Жаредын ахад хандан хэлсэн нь: Та нар хөлгүүд дотроо гэрэлтэй байхын тулд намайг хэрхэхийг та нар хүснэ вэ? Учир нь болгоогтун, та нар хөлөгтөө цонхтой байж үл болно, учир нь тэдгээр нь хэдэн хэсэг бутрах болно; бас та нар өөрсөдтэйгөө гал авч явж үл болно, учир нь та нар галын гэрлээр явахгүй.
- 24 Учир нь болгоогтун, та нар далайн дундах халимтай адил байх болно; учир нь уулс мэт давалгаанууд та нар дээр буух болно. Гэсэн хэдий ч, би та нарыг далайн гүнээс дахин гаргаж ирэх болно; учир нь салхи амнаас минь гарч, мөн бас бороо болоод үерийг ч би илгээх болой.
- 25 Мөн болгоогтун, би та нарыг эдгээр зүйлсийн эсрэг бэлтгэх болно; учир нь би та нарыг далайн давалгаа, мөн урагш түрэх салхи, мөн ирэх үерийн эсрэг эс бэлтгэх аваас та нар энэхүү агуу гүнийг гаталж эс чадна. Тиймийн тул та нар далайн гүнд хучигдахын цагт та нар гэрэлтэй байхын тулд намайг та нар юу бэлтгээсэй хэмээн хүсч байна вэ

And it came to pass that the brother of Jared did so, according as the Lord had commanded.

And he cried again unto the Lord saying: O Lord, behold I have done even as thou hast commanded me; and I have prepared the vessels for my people, and behold there is no light in them. Behold, O Lord, wilt thou suffer that we shall cross this great water in darkness?

And the Lord said unto the brother of Jared: What will ye that I should do that ye may have light in your vessels? For behold, ye cannot have windows, for they will be dashed in pieces; neither shall ye take fire with you, for ye shall not go by the light of fire.

For behold, ye shall be as a whale in the midst of the sea; for the mountain waves shall dash upon you. Nevertheless, I will bring you up again out of the depths of the sea; for the winds have gone forth out of my mouth, and also the rains and the floods have I sent forth.

And behold, I prepare you against these things; for ye cannot cross this great deep save I prepare you against the waves of the sea, and the winds which have gone forth, and the floods which shall come. Therefore what will ye that I should prepare for you that ye may have light when ye are swallowed up in the depths of the sea?

## Ифер 3

- 1 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах (эдүгээ бэлтгэсэн хөлгийн тоо нь найм байв), үлэмж өндөр болохынх нь учир Шелем уул хэмээн тэдний нэрлэсэн уул өөд очиж, мөн хаднаас арван зургаан жижиг чулууг хайлуулан гаргаж авав; мөн тэдгээр нь цагаан бөгөөд тунгалаг, бүр нэвт харагдах шил лугаа адил байв; мөн уулын орой дээр тэрээр тэдгээрийг гартаа барин, мөн Их Эзэнд хандан залбирч хэлрүүн:
- 2 Ай Их Эзэн, та биднийг ус үерт хүрээлэгдэх ёстой хэмээн хэлсэн. Эдүгээ болгоогтун, Ай Их Эзэн, мөн таны өмнөх сул доройгоос нь болоод үйлчлэгчдээ бүү хилэгнээч; учир нь та бол ариун мөн тэнгэрт оршдог, мөн таны өмнө зохисгүйгээ бид мэднэ; уналтын улмаас бидний төрөлхийн чанар үргэлжид хилэнцэт байхаар болсон юм; гэсэн хэдий ч, Ай Их Эзэн, танаас бид хүслийнхээ дагуу хүлээн авч болохын тулд бид таныг дуудах учиртай хэмээх зарлигийг та бидэнд өгсөн буюу.
- 3 Болгоогтун, Ай Их Эзэн, бидний алдсын улмаас та биднийг гэсгээсэн, мөн биднийг нүүлгэсэн, мөн энэ олон жилийн туршид бид аглаг буйдад л байлаа; гэсэн хэдий ч, та бидэнд нигүүлсэнгүй хандаж байсан. Ай Их Эзэн, намайг өрөвдөн хараач, мөн өөрийн энэ хүмүүсээс та уур хилэнгээ холдуулаач, мөн энэ догшин гүнийг тэд харанхуйд гатлахыг бүү зөвшөөрөөч; харин хаднаас миний хайлуулан гаргасан эдгээр зүйлсийг болгооно уу.
- 4 Мөн, Ай Их Эзэн, та бүх хүчийг эзэмшдэг, мөн хүмүүний тусын тулд та ямарвааг хийж чадна гэдгийг би мэднэ; тиймийн тул эдгээр чулуунд хуруугаараа хүрээч, Ай Их Эзэн, тэдгээр нь харанхуйд гэрэлтэж болохын тулд; мөн далайг гатлахдаа бид гэрэлтэй байж болохын тулд тэдгээрийг бэлтгээч, тэдгээр нь бидний бэлтгэсэн хөлгүүд дотор бидэнд гэрэл өгөх болно.
- 5 Болгоогтун, Ай Их Эзэн, та үүнийг хийж чадна шүү дээ. Та, хүмүүсийн ойлголтонд өчүүхэн мэт харагддаг агуу хүчийг үзүүлж чадахыг бид мэднэ.

## Ether 3

And it came to pass that the brother of Jared, (now the number of the vessels which had been prepared was eight) went forth unto the mount, which they called the mount Shelem, because of its exceeding height, and did molten out of a rock sixteen small stones; and they were white and clear, even as transparent glass; and he did carry them in his hands upon the top of the mount, and cried again unto the Lord, saying:

O Lord, thou hast said that we must be encompassed about by the floods. Now behold, O Lord, and do not be angry with thy servant because of his weakness before thee; for we know that thou art holy and dwellest in the heavens, and that we are unworthy before thee; because of the fall our natures have become evil continually; nevertheless, O Lord, thou hast given us a commandment that we must call upon thee, that from thee we may receive according to our desires.

Behold, O Lord, thou hast smitten us because of our iniquity, and hast driven us forth, and for these many years we have been in the wilderness; nevertheless, thou hast been merciful unto us. O Lord, look upon me in pity, and turn away thine anger from this thy people, and suffer not that they shall go forth across this raging deep in darkness; but behold these things which I have molten out of the rock.

And I know, O Lord, that thou hast all power, and can do whatsoever thou wilt for the benefit of man; therefore touch these stones, O Lord, with thy finger, and prepare them that they may shine forth in darkness; and they shall shine forth unto us in the vessels which we have prepared, that we may have light while we shall cross the sea.

Behold, O Lord, thou canst do this. We know that thou art able to show forth great power, which looks small unto the understanding of men.

- 6 Мөнхүү улиран тохиох дор Жаредын ах эдгээр үгсийг хэлэхэд, болгоогтун, Их Эзэн мутраа сунган мөн чулуунуудад нэг нэгээр нь хуруугаараа хүрэв. Мөн Жаредын ахын нүднээс гивлүүр сөхөгдөхөд, мөн Их Эзэний хурууг тэр харлаа; мөн энэ нь хүмүүний хуруутай адил, мах цустай мэт байв; мөн Жаредын ах Их Эзэний өмнө унав, учир нь тэрээр айдаст хүлэгдсэн ажгуу.
- 7 Мөн Их Эзэн Жаредын ах газарт унасныг харж; мөн Их Эзэн түүнд хандан хэлэв: Бос, чи юунд унав
- 8 Мөн тэрээр Их Эзэнд хандан өчиж: Их Эзэний хурууг би харлаа, мөн тэр намайг цохих вий хэмээн айв би; Их Эзэн мах цустайг би эс мэдсэний учир буюу.
- 9 Мөн Их Эзэн түүнд хандан хэлсэн нь: Итгэлийн чинь улмаас би өөртөө мах цусыг авах болно гэдгийг чи харлаа; мөн чиний нэгэн адил ийм үлэмж итгэлтэйгээр хүмүүн миний өмнө хэзээ ч ирж байсангүй; тийм бус аваас чи миний хурууг харж чадахгүй байсан. Чи үүнээс өөрийг харав уу
- 10 Мөн тэрээр хариулсан нь: Үгүй; Их Эзэн, өөрийгөө надад үзүүлээч.
- 11 Мөн Их Эзэн түүнд хандан хэлрүүн: Миний ярих үгсэд чи итгэх үү
- 12 Мөн тэрээр хариулсан нь: Тийм ээ, Их Эзэн, та үнэнийг ярьж буйг, учир нь та үнэний Бурхан болохыг, мөн худал хэлж эс чадахыг би мэднэ.
- 13 Мөн тэрээр эдгээр үгсийг хэлэхэд, болгоогтун, Их Эзэн өөрийгөө түүнд үзүүлэн, мөн хэлсэн нь: Чи эдгээр зүйлсийг мэдэхийн учир чи уналтаас гэтэлгэгдсэн болой; тиймийн тул чи миний дэргэд буцаан хүргэгдлээ; тиймийн тул би чамд өөрийгөө үзүүлж буй.
- 14 Болгоогтун, өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр дэлхийн үүслээс бэлтгэгдсэн нь би болой. Болгоогтун, бибээр Есүс Христ. Бибээр Эцэг мөн Хүү. Надаар бүх хүмүүн төрөлхтөн амьдралыг, бүр миний нэрэнд итгэх тэд мөнхийн түүнийг хүртэх болно; мөн тэд миний охид, мөн миний хөвгүүд болох болно.

And it came to pass that when the brother of Jared had said these words, behold, the Lord stretched forth his hand and touched the stones one by one with his finger. And the veil was taken from off the eyes of the brother of Jared, and he saw the finger of the Lord; and it was as the finger of a man, like unto flesh and blood; and the brother of Jared fell down before the Lord, for he was struck with fear.

And the Lord saw that the brother of Jared had fallen to the earth; and the Lord said unto him: Arise, why hast thou fallen?

And he saith unto the Lord: I saw the finger of the Lord, and I feared lest he should smite me; for I knew not that the Lord had flesh and blood.

And the Lord said unto him: Because of thy faith thou hast seen that I shall take upon me flesh and blood; and never has man come before me with such exceeding faith as thou hast; for were it not so ye could not have seen my finger. Sawest thou more than this?

And he answered: Nay; Lord, show thyself unto me.

And the Lord said unto him: Believest thou the words which I shall speak?

And he answered: Yea, Lord, I know that thou speakest the truth, for thou art a God of truth, and canst not lie.

And when he had said these words, behold, the Lord showed himself unto him, and said: Because thou knowest these things ye are redeemed from the fall; therefore ye are brought back into my presence; therefore I show myself unto you.

Behold, I am he who was prepared from the foundation of the world to redeem my people. Behold, I am Jesus Christ. I am the Father and the Son. In me shall all mankind have life, and that eternally, even they who shall believe on my name; and they shall become my sons and my daughters.

- 15 Мөн чиний нэгэн адилаар надад хүмүүн итгэж байсан нь үгүйн учир, өөрийн бүтээсэн хүмүүндээ, би хэзээ ч өөрийгөө үзүүлж байсан нь үгүй. Миний өөрийн төрхөөр чи бүтээгдсэн болохоо харж байна уу? Тийм ээ, бүр бүх хүмүүс эхлэлд миний өөрийн төрхөөр бүтээгдсэн билээ.
- 16 Болгоогтун, чиний болгоож буй энэ бие болбоос миний сүнсний бие; мөн хүмүүнийг би өөрийн сүнсний биеийн адилаар бүтээсэн юм; мөн би сүнсэндээ чиний өмнө үзэгдэж буй ч би өөрийн хүмүүст маханбодиороо үзэгдэх болно.
- 17 Мөн эдүгээ, би, Моронай, эдгээр бичигдсэн зүйлүүдийн бүхэл шастирыг үйлдэж чадахгүйгээ би хэлсэн учир, тиймийн тул, бүр нифайчуудад өөрийгөө үзүүлснийхээ адил биеийн төрхөөр мөн маягаар, Есүс өөрийгөө энэ хүмүүнд сүнсээрээ үзүүлсэн хэмээн хэлэх нь надад хангалттай юм.
- 18 Мөн тэрээр нифайчуудад тохинуулсныхаа адилаар түүнд тохинуулсан билээ; мөн энэ бүхэн, Их Эзэн түүнд үзүүлсэн олон агуу үйлсийн улмаас, энэ хүмүүн тэрбээр Бурхан болохыг мэдэж болохын тулд хийгдсэн буюу.
- 19 Мөн энэ хүмүүний мэдлэгийн улмаас тэрээр гивлүүрийн доторхыг нэвт харах гүйгээр хадгалагдах аргагүй юм; мөн тэрээр Есүсийн хурууг харсан байв, түүнийг тэрээр хараад, энэ нь Их Эзэний хуруу болохыг тэрээр мэдсэн учир, тэр айдастайгаар унасан ажгуу; мөн тэрээр ямар ч эргэлзээгүйгээр мэдэж байсан учир, тэрээр цаашид итгэхгүй байх аргагүй болжээ.
- 20 Иймийн тул, Бурханы энэ төгс мэдлэгийг агуулсны учир, тэрээр гивлүүрийн дотор хадгалагдах аргагүй юм; тиймийн тул тэрээр Есүсийг харсан; мөн тэрбээр түүнд тохинуулсан буюу.
- 21 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Жаредын ахад хандан хэлрүүн: Болгоогтун, чи өөрийн үзсэн мөн сонссон эдгээр зүйлсийг, би өөрийн нэрийг маханбодиороо алдаршуулах тэр цаг ирэх хүртэл, дэлхийнхэнд мэдэгдэхийг үл зөвшөөрөгтүн; иймийн тул, чи өөрийн үзсэн мөн сонссон зүйлсээ нандигнан хадгалах болно, мөн ямар ч хүмүүнд бүү үзүүлсүгэй.

And never have I showed myself unto man whom I have created, for never has man believed in me as thou hast. Seest thou that ye are created after mine own image? Yea, even all men were created in the beginning after mine own image.

Behold, this body, which ye now behold, is the body of my spirit; and man have I created after the body of my spirit; and even as I appear unto thee to be in the spirit will I appear unto my people in the flesh.

And now, as I, Moroni, said I could not make a full account of these things which are written, therefore it sufficeth me to say that Jesus showed himself unto this man in the spirit, even after the manner and in the likeness of the same body even as he showed himself unto the Nephites.

And he ministered unto him even as he ministered unto the Nephites; and all this, that this man might know that he was God, because of the many great works which the Lord had showed unto him.

And because of the knowledge of this man he could not be kept from beholding within the veil; and he saw the finger of Jesus, which, when he saw, he fell with fear; for he knew that it was the finger of the Lord; and he had faith no longer, for he knew, nothing doubting.

Wherefore, having this perfect knowledge of God, he could not be kept from within the veil; therefore he saw Jesus; and he did minister unto him.

And it came to pass that the Lord said unto the brother of Jared: Behold, thou shalt not suffer these things which ye have seen and heard to go forth unto the world, until the time cometh that I shall glorify my name in the flesh; wherefore, ye shall treasure up the things which ye have seen and heard, and show it to no man.

- 22 Мөн болгоогтун, чи надад ирэхдээ, тэдгээрийг чи бичиж, мөн хэн ч хөрвүүлж эс чадахын тулд; тэдгээр нь уншигдаж чадахааргүй тийм хэл дээр чи тэдгээрийг бичихийн учир чи тэдгээрийг лацдах болно.
- 23 Мөн болгоогтун, энэ хоёр чулууг би чамд өгье, мөн чи бичих тэр зүйлүүдтэй хамт түүнчлэн тэдгээрийг чи лацдах болно.
- 24 Учир нь болгоогтун, чиний бичих тэр хэлийг би будлиулсан; иймийн тул би өөрийн зохих цагт чиний бичих эдгээр зүйлүүдийг хүмүүсийн нүдэнд эдгээр чулуунууд тодруулахаар болгоно.
- 25 Мөн Их Эзэн эдгээр үгсийг хэлээд, тэрбээр Жаредын ахад, өмнө нь байсан дэлхийн бүх оршин суугчдыг, мөн түүнчлэн цаашид байх бүгдийг үзүүлэв; мөн бүр дэлхийн төгсгөлийг хүртэлх тэднийг түүний нүднээс тэрбээр далдалсан нь үгүй.
- 26 Хэрэв тэрээр өөрт нь итгэх аваас тэрээр түүнд бүх зүйлийг үзүүлж чадна хэмээн тэрбээр түүнд өмнөх үед хэлсний учир— тэр нь түүнд үзүүлэгдэх болно, тиймийн тул тэрээр Их Эзэн өөрт нь бүгдийг үзүүлж чадна гэдгийг мэдсэн учир, Их Эзэн түүнээс юуг ч нууж чадсангүй ажээ.
- 27 Мөн Их Эзэн түүнд хандан хэлрүүн: Эдгээр зүйлийг бичигтүн мөн тэдгээрийг лацдагтун; мөн би тэдгээрийг өөрийн зохих цагт хүмүүний үрст үзүүлэх болно.
- 28 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүлээж авсан хоёр чулуугаа лацдаж, мөн Их Эзэн хүмүүний үрст үзүүлэх хүртэл тэдгээрийг үзүүлэхгүй байхыг Их Эзэн түүнд зарлиглав.

And behold, when ye shall come unto me, ye shall write them and shall seal them up, that no one can interpret them; for ye shall write them in a language that they cannot be read.

And behold, these two stones will I give unto thee, and ye shall seal them up also with the things which ye shall write.

For behold, the language which ye shall write I have confounded; wherefore I will cause in my own due time that these stones shall magnify to the eyes of men these things which ye shall write.

And when the Lord had said these words, he showed unto the brother of Jared all the inhabitants of the earth which had been, and also all that would be; and he withheld them not from his sight, even unto the ends of the earth.

For he had said unto him in times before, that if he would believe in him that he could show unto him all things—it should be shown unto him; therefore the Lord could not withhold anything from him, for he knew that the Lord could show him all things.

And the Lord said unto him: Write these things and seal them up; and I will show them in mine own due time unto the children of men.

And it came to pass that the Lord commanded him that he should seal up the two stones which he had received, and show them not, until the Lord should show them unto the children of men.

## Ифер 4

- 1 Мөнхүү Их Эзэний дэргэдээс холдон уулнаас доошлон бууж, мөн үзсэн зүйлүүдээ бичихийг Их Эзэн Жаредын ахад зарлиглав; мөн түүнийг загалмай дээр өргөгдсөний дарааг хүртэл хүмүүний үрсэд тэдгээрийн ирэх нь хориглогдов, мөн энэ шалтгааны улмаас Христ өөрийн хүмүүст өөрийгөө үзүүлэх хүртэл тэдгээр нь дэлхийд үл ирэхийн тулд Мозая хаан тэдгээрийг хадгалжээ.
- 2 Мөн Христ өөрийгөө үнэхээр өөрийн хүмүүст үзүүлсний дараа тэрээр тэдгээр нь илэрхийлэгдэхийг зарлиг болгов.
- 3 Мөн эдүгээ, түүний дараа, тэд бүгд итгэлгүйдээ бууран доройтсон ажээ; мөн леменчүүдээс өөр хэн ч байсангүй, мөн тэд Есүс Христийн сайн мэдээг эсэргүүцэв; тиймийн тул тэдгээрийг дахин газарт нуухаар би зарлиг болгогдов.
- 4 Болгоогтун, эдгээр ялтсууд дээр би Жаредын ахын үзсэн чухамхүү тэдгээр зүйлүүдийг бичсэн болой; мөн Жаредын ахад илэрхийлэгдсэн тэдгээрээс илүү агуу зүйлүүд хэзээ ч илэрхийлэгдэж байсангүй.
- 5 Иймийн тул тэдгээрийг бичихийг Их Эзэн надад зарлигласан; мөн би тэдгээрийг бичив. Мөн намайг тэдгээрийг лацдахыг тэрээр зарлиг болгосон буюу; мөн тэрбээр тэдгээрийн хөрвүүлгийг түүнчлэн лацдахыг зарлиг болгосон; иймийн тул Их Эзэний зарлигийн дагуу, би хөрвүүлэгчдийг лацадсан билээ.
- 6 Учир нь Их Эзэн надад хандаж хэлрүүн: Тэд алдсаа наманчилж, мөн Их Эзэний өмнө цэвэр болох тэр өдрийг хүртэл тэдгээр нь харийнханд очихгүй.
- 7 Мөнхүү Их Эзэн өгүүлэн, тэд надаар ариусгагдаж болохын тулд, бүр Жаредын ахын үйлдсэн лугаа адил, надад итгэх итгэлээ хэрэглэх тэр өдөр, тэгээд би бүр бүх илчлэлтүүдээ тэдэнд мэдүүлэх хүртэл Жаредын ахын үзсэн зүйлүүдийг илэрхийлэх болно хэмээн Есүс Христ, Бурханы Хүү, тэнгэр ба газрын мөн тэдгээрт буй бүх зүйлүүдийн Эцэг хэлдэг бөлгөө.
- 8 Мөн Их Эзэний үгийн эсрэг мэтгэлцэх тэр нь, тэрээр зүхэгдэг; мөн эдгээр зүйлийг үгүйсгэх тэр нь, тэрээр зүхэгдэг; учир нь би тэдэнд илүү агуу зүйлийг үзүүлэх нь үгүй хэмээн Есүс Христ хэлдэг; учир нь ярьдаг тэр нь би бээр юм.

## Ether 4

And the Lord commanded the brother of Jared to go down out of the mount from the presence of the Lord, and write the things which he had seen; and they were forbidden to come unto the children of men until after that he should be lifted up upon the cross; and for this cause did king Mosiah keep them, that they should not come unto the world until after Christ should show himself unto his people.

And after Christ truly had showed himself unto his people he commanded that they should be made manifest.

And now, after that, they have all dwindled in unbelief; and there is none save it be the Lamanites, and they have rejected the gospel of Christ; therefore I am commanded that I should hide them up again in the earth.

Behold, I have written upon these plates the very things which the brother of Jared saw; and there never were greater things made manifest than those which were made manifest unto the brother of Jared.

Wherefore the Lord hath commanded me to write them; and I have written them. And he commanded me that I should seal them up; and he also hath commanded that I should seal up the interpretation thereof; wherefore I have sealed up the interpreters, according to the commandment of the Lord.

For the Lord said unto me: They shall not go forth unto the Gentiles until the day that they shall repent of their iniquity, and become clean before the Lord.

And in that day that they shall exercise faith in me, saith the Lord, even as the brother of Jared did, that they may become sanctified in me, then will I manifest unto them the things which the brother of Jared saw, even to the unfolding unto them all my revelations, saith Jesus Christ, the Son of God, the Father of the heavens and of the earth, and all things that in them are.

And he that will contend against the word of the Lord, let him be accursed; and he that shall deny these things, let him be accursed; for unto them will I show no greater things, saith Jesus Christ; for I am he who speaketh.

- 9 Мөн миний зарлигаар тэнгэр нээгдэж, мөн хаагдаг; мөн миний үгээр дэлхий чичирдэг; мөн миний зарлигаар түүний оршин суугчид галаар лугаа адил устгагдана.
- 10 Мөн миний үгсэд эс итгэх тэр нь миний шавь нарт итгэдэггүй; мөн намайг ярьсан эсэхийг, та нар шүүн тунгаагтун; учир нь эцсийн өдөр, ярьж байсан нь би болохыг та нар мэдэх болно.
- 11 Гэвч миний ярьсан эдгээр зүйлсэд итгэх, түүнд би Сүнснийхээ илэрхийлэлтээр айлчлах болно, мөн тэрээр мэдэж мөн гэрчлэх болно. Учир нь миний Сүнсний улмаас тэрээр эдгээр зүйлүүд үнэнийг тэрээр мэднэ; учир нь энэ нь хүмүүсийг сайныг үйлдэхэд ятгадаг.
- 12 Мөн хүмүүсийг сайныг үйлдэхэд ятгадаг аливаа зүйл нь надаас юм; сайн нь надаас бус бол өөр хэнээс ч эс ирдгийн учир буюу. Хүмүүсийг сайн бүхний зүг хөтөлдөг чухамхүү тэр нь би юм; миний үгэнд эс итгэх тэр нь надад—итгэхгүй байх болно; мөн надад итгэхгүй тэр нь намайг илгээсэн Эцэгт итгэхгүй байх болно. Учир нь болгоогтун, би бол Эцэг, би бол дэлхийн гэрэл ба амь, мөн үнэн болой.
- 13 Надад ирэгтүн, Ай харийнхан та нар, мөн би та нарт илүү агуу тэрхүү зүйлүүдийг, итгэлгүй байдлын улмаас далдлагдсан мэдлэгийг та нарт үзүүлэх болно.
- 14 Надад ирэгтүн, Ай Израилын угсаа та нар, мөн дэлхийн үүслээс, Эцэг та нарт бэлтгэсэн зүйлс ямар агуу болох нь та нарт илэрхийлэгдэх болно; мөн итгэлгүй байдлын улмаас энэ нь та нарт мэдэгдээгүй буюу.
- 15 Болгоогтун, та нарын ёс бусын аймшигт байдалдаа, мөн сэтгэлийн хатуу, мөн оюуны харалгандаа үлдэх шалтгаан болж буй тэрхүү үл итгэх байдлын гивлүүрийг та нар тас татахад, тэгээд дэлхийн үүслээс эхлэн та нараас нууцлагдаж байсан тэр агуу мөн гайхамшигт зүйлийг, тийм ээ, та нар харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр, миний нэрээр, Эцэгт хандан залбирахад, тэгэхэд Ай Израилын угсаа, та нарын эцэг өвгөдтэй хийсэн гэрээгээ Эцэг санасныг та нар мэдэх болно.

And at my command the heavens are opened and are shut; and at my word the earth shall shake; and at my command the inhabitants thereof shall pass away, even so as by fire.

And he that believeth not my words believeth not my disciples; and if it so be that I do not speak, judge ye; for ye shall know that it is I that speaketh, at the last day.

But he that believeth these things which I have spoken, him will I visit with the manifestations of my Spirit, and he shall know and bear record. For because of my Spirit he shall know that these things are true; for it persuadeth men to do good.

And whatsoever thing persuadeth men to do good is of me; for good cometh of none save it be of me. I am the same that leadeth men to all good; he that will not believe my words will not believe me—that I am; and he that will not believe me will not believe the Father who sent me. For behold, I am the Father, I am the light, and the life, and the truth of the world.

Come unto me, O ye Gentiles, and I will show unto you the greater things, the knowledge which is hid up because of unbelief.

Come unto me, O ye house of Israel, and it shall be made manifest unto you how great things the Father hath laid up for you, from the foundation of the world; and it hath not come unto you, because of unbelief.

Behold, when ye shall rend that veil of unbelief which doth cause you to remain in your awful state of wickedness, and hardness of heart, and blindness of mind, then shall the great and marvelous things which have been hid up from the foundation of the world from you—yea, when ye shall call upon the Father in my name, with a broken heart and a contrite spirit, then shall ye know that the Father hath remembered the covenant which he made unto your fathers, O house of Israel.



16 Мөн тэгээд би өөрийн үйлчлэгч Иоханаар бичүүлсэн миний илчлэлтүүд бүх хүмүүсийн нүдний өмнө дэлгэгдэх болно. Санагтун, та нар эдгээр зүйлийг харахдаа, тэдгээр нь чухамхүү бодит байдлаар үзүүлэгдэх цаг ойрхон ирээд буйг та нар мэдэх болно.

17 Тиймийн тул, та нар энэ цэдгийг хүлээн аваад Эцэгийн ажил уг нутгийн бүх гадаргуу дээр эхэлсэн болохыг та нар мэдэж болно.

18 Тиймийн тул, дэлхийн бүх хязгаарууд та нар наманчлагтун, мөн надад ирэгтүн, мөн сайн мэдээнд минь итгэгтүн, мөн миний нэрээр баптисм хүртэгтүн; учир нь итгэн мөн баптисм хүртсэн нь аврагдах болно; гэвч үл итгэх тэр нь яллагдах болно; мөн миний нэрэнд итгэх тэднийг тэмдгүүд дагалдах болно.

19 Мөн эцсийн өдөр миний нэрэнд итгэлтэй хэвээр байх адислагдсан болой, учир нь тэр нь дэлхийн үүслээс түүнд зориулагдан бэлтгэгдсэн хаант улсад оршин байхаар тэр өргөгдөх болно. Мөн болгоогтун үүнийг ярьсан нь би болой. Амен.

And then shall my revelations which I have caused to be written by my servant John be unfolded in the eyes of all the people. Remember, when ye see these things, ye shall know that the time is at hand that they shall be made manifest in very deed.

Therefore, when ye shall receive this record ye may know that the work of the Father has commenced upon all the face of the land.

Therefore, repent all ye ends of the earth, and come unto me, and believe in my gospel, and be baptized in my name; for he that believeth and is baptized shall be saved; but he that believeth not shall be damned; and signs shall follow them that believe in my name.

And blessed is he that is found faithful unto my name at the last day, for he shall be lifted up to dwell in the kingdom prepared for him from the foundation of the world. And behold it is I that hath spoken it. Amen.

## Ифер 5

- 1 Мөн эдүгээ би, Моронай, ой ухааныхаа дагуу, надад зарлиг болгосон үгсийг бичсэн буюу; мөн би лацадсан зүйлүүдээ танд хэлсэн бөлгөө; тиймийн тул та нар орчуулж болно хэмээн тэдгээрийг бүү хөндөгтүн; учир нь хэзээ нэгэн цагт энэ нь Бурханы мэргэн ухаанд байхаас бусдаар, тэр зүйл та нарт хориглогдсон болой.
- 2 Мөн болгоогтун, энэ ажлыг авчрахад туслах тэдэнд уг ялтсуудыг та нар үзүүлж болно хэмээн та нар эрх авч магадгүй юм;
- 3 Мөн Бурханы хүчээр гуравт тэдгээр нь үзэгдэх болно; иймийн тул тэд эдгээр зүйлүүд үнэнийг гарцаагүйгээр мэдэх болно.
- 4 Мөнхүү гурван гэрчийн амаар эдгээр зүйлүүд нотлогдох болно; мөн гурвын гэрчлэл, мөн ажил, түүгээр Бурханы хүч, мөн түүнчлэн Эцэг, мөн Хүү, мөн Ариун Сүнс гэрчлэх түүний үг үзүүлэгдэх тэр—мөн энэ бүхэн нь эцсийн өдөр дэлхийнхний эсрэг гэрчлэл болон зогсох болно.
- 5 Мөн хэрэв тэд наманчилж мөн Есүсийн нэрээр Эцэгт ирэх аваас, тэд Бурханы хаант улсад хүлээн авагдах болно.
- 6 Мөн эдүгээ, хэрэв эдгээр зүйлүүдэд надад эрх мэдэл буй эсэхийг, та нар шүүн тунгаагтун; учир нь намайг харахад надад эрх мэдэл буйг та нар мэдэх болно, мөн бид эцсийн өдөр Бурханы өмнө зогсох болно. Амен.

## Ether 5

And now I, Moroni, have written the words which were commanded me, according to my memory; and I have told you the things which I have sealed up; therefore touch them not in order that ye may translate; for that thing is forbidden you, except by and by it shall be wisdom in God.

And behold, ye may be privileged that ye may show the plates unto those who shall assist to bring forth this work;

And unto three shall they be shown by the power of God; wherefore they shall know of a surety that these things are true.

And in the mouth of three witnesses shall these things be established; and the testimony of three, and this work, in the which shall be shown forth the power of God and also his word, of which the Father, and the Son, and the Holy Ghost bear record—and all this shall stand as a testimony against the world at the last day.

And if it so be that they repent and come unto the Father in the name of Jesus, they shall be received into the kingdom of God.

And now, if I have no authority for these things, judge ye; for ye shall know that I have authority when ye shall see me, and we shall stand before God at the last day. Amen.

## Ифер 6

- 1 Мөн эдүгээ, би, Моронай, Жаред болон түүний ахын цэдгийг үргэлжлүүлсүгэй.
- 2 Учир нь улиран тохиох дор уул өөд Жаредын ахын өргөж гаргасан чулуунуудыг бэлтгэсний дараа, Жаредын ах уулан дээрээс буун ирж, мөн тэрээр бэлтгэгдсэн хөлгүүд дотроо уг чулуунуудыг Их Эзэн хоёр үзүүрт нь нэг нэгийг тавьжээ; мөн болгоогтун, тэдгээр нь хөлгүүдэд гэрэл өгсөн ажээ.
- 3 Мөн тийн Их Эзэн чулуунуудыг харанхуйд гэрэлтэн, эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд, тэд их усыг харанхуйд гатлахгүй байж болохын тулд, гэрэл өгөх болгосон бөлгөө.
- 4 Мөнхүү улиран тохиох дор тэд усан дээр амь зууж болохын тулд, тэд бүхий л төрлийн хоол ундыг, мөн бог болон бод малдаа хүнс тэжээлийг мөн өөрсөдтэйгөө авч явах ёстой аливаа амьтан жигүүртнийг бэлтгээд—мөнхүү улиран тохиох дор эдгээр бүх зүйлийг гүйцэлдүүлснийхээ дараа тэд хөлөг онгоц мөн усан онгоцон дээрээ гарцгаан, мөн өөрсдийгөө Их Эзэн Бурхандаа даатгаад, далайд хөвж одов.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн Бурхан, амлагдсан нутгийн зүг усан дээгүүр ширүүн салхи үлээж байхаар болгосон аж; мөн тийн тэд салхины өмнө далайн давалгаанд шидэгдэн явав.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэдний дээр задрах уулс мэт давалгаанууд, мөн түүнчлэн салхины догшноос үүссэн агуу хийгээд аймшигт их шуургануудаас болон далайн гүнд тэд олонтаа автагдсан бөлгөө.
- 7 Мөнхүү улиран тохиох дор тэдний хөлөг таваг лугаа адил нягт, мөн тэд Ноагийн хөлөг онгоц лугаа адил нягт байсан тул гүнд автагдахад нь ус тэднийг огтхон ч гэмтээж эс чадав; тиймийн тул тэд их усанд хучигдсан үедээ Их Эзэнд залбиран гуйж, мөн тэрбээр тэднийг дахин усны мандал дээр гаргаж байв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэднийг усны мандал дээр байх үест салхи амлагдсан нутаг тийш үлээхээ хэзээ ч зогссонгүй; мөн тийн тэд салхины өмнө урагш туугдсан авай.

## Ether 6

And now I, Moroni, proceed to give the record of Jared and his brother.

For it came to pass after the Lord had prepared the stones which the brother of Jared had carried up into the mount, the brother of Jared came down out of the mount, and he did put forth the stones into the vessels which were prepared, one in each end thereof; and behold, they did give light unto the vessels.

And thus the Lord caused stones to shine in darkness, to give light unto men, women, and children, that they might not cross the great waters in darkness.

And it came to pass that when they had prepared all manner of food, that thereby they might subsist upon the water, and also food for their flocks and herds, and whatsoever beast or animal or fowl that they should carry with them—and it came to pass that when they had done all these things they got aboard of their vessels or barges, and set forth into the sea, commending themselves unto the Lord their God.

And it came to pass that the Lord God caused that there should be a furious wind blow upon the face of the waters, towards the promised land; and thus they were tossed upon the waves of the sea before the wind.

And it came to pass that they were many times buried in the depths of the sea, because of the mountain waves which broke upon them, and also the great and terrible tempests which were caused by the fierceness of the wind.

And it came to pass that when they were buried in the deep there was no water that could hurt them, their vessels being tight like unto a dish, and also they were tight like unto the ark of Noah; therefore when they were encompassed about by many waters they did cry unto the Lord, and he did bring them forth again upon the top of the waters.

And it came to pass that the wind did never cease to blow towards the promised land while they were upon the waters; and thus they were driven forth before the wind.

9 Мөн тэд Их Эзэнийг магтан дуулж байв; тийм ээ, Жаредын ах Их Эзэнийг магтан дуулсан буюу, мөн тэрээр бүх л өдрийн турш Их Эзэнд талархан мөн магтаж байв, мөн шөнө болоход, тэд Их Эзэнийг магтахаа зогссонгүй.

10 Мөн тийн тэд урагш туугдаж байв; мөн далайн ямар ч мангас тэднийг сүйтгэж, ямар ч халим тэднийг гэмтээж чадсангүй; мөн тэд усан дээр ч, мөн усан дор ч байсан тэд үргэлжид гэрэлтэй байлаа.

11 Мөн тийн тэд гурван зуун дөчин дөрвөн өдөр усан дээр урагш туугджээ.

12 Мөн тэд амлагдсан нутгийн эрэгт газардав. Мөн амлагдсан нутгийн эрэгт тэд хөл тавиад, тэдэнд түүний үзүүлсэн эрхэм их нигүүлслийн улмаас, тэд газрын гадаргуу доош өөрсдөө мэхийн, мөн Их Эзэний өмнө өөрсдийгөө даруусган, мөн Их Эзэний өмнө баяр хөөрийн нулимс дуслуулсан бөлгөө.

13 Мөнхүү улиран тохиох дор тэд нутгийн гадаргуу дээгүүр явж, мөн газраа боловсруулж эхлэв.

14 Мөн Жаред дөрвөн хүүтэй болов, мөн тэд Жеком, мөн Гилга, мөн Маха, мөн Ораиха хэмээн нэрлэгдсэн бөлгөө.

15 Мөн Жаредын ах нь түүнчлэн хөвгүүд охидтой болсон ажгуу.

16 Мөн Жаредын мөн түүний ахын найзууд хорин хоёр тооны бодгаль байлаа; мөн тэд түүнчлэн амлагдсан нутагт ирэхийнхээ өмнө хөвгүүд охидыг төрүүлсэн бөлгөө; мөн тиймийн тул тэд олон болж эхлэв.

17 Мөн тэд Их Эзэний өмнө даруухнаар алхахыг заалгав; мөн тэд дээрээс түүнчлэн заалгасан байв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд нутгийн гадаргуу дээгүүр тархаж, мөн үржиж мөн газраа боловсруулж эхлэн; мөн нутагтаа тэд хүчирхэгжжээ.

19 Мөн Жаредын ах нь өтөлж эхлэн, мөн тэр удахгүй доош булшинд орохоор явах ёстойгоо ухаарсан аж; иймийн тул тэр Жаредад хандан хэлрүүн: Бид тэднийг тоолон, түүнчлэн биднийг булшиндаа орохоос өмнө тэд биднээс юу хүсэхийг нь тэднээс бид мэдэж болохын тулд өөрсдийн хүмүүсийг цуглуулцгаая.

And they did sing praises unto the Lord; yea, the brother of Jared did sing praises unto the Lord, and he did thank and praise the Lord all the day long; and when the night came, they did not cease to praise the Lord.

And thus they were driven forth; and no monster of the sea could break them, neither whale that could mar them; and they did have light continually, whether it was above the water or under the water.

And thus they were driven forth, three hundred and forty and four days upon the water.

And they did land upon the shore of the promised land. And when they had set their feet upon the shores of the promised land they bowed themselves down upon the face of the land, and did humble themselves before the Lord, and did shed tears of joy before the Lord, because of the multitude of his tender mercies over them.

And it came to pass that they went forth upon the face of the land, and began to till the earth.

And Jared had four sons; and they were called Jacom, and Gilgah, and Mahah, and Orihah.

And the brother of Jared also begat sons and daughters.

And the friends of Jared and his brother were in number about twenty and two souls; and they also begat sons and daughters before they came to the promised land; and therefore they began to be many.

And they were taught to walk humbly before the Lord; and they were also taught from on high.

And it came to pass that they began to spread upon the face of the land, and to multiply and to till the earth; and they did wax strong in the land.

And the brother of Jared began to be old, and saw that he must soon go down to the grave; wherefore he said unto Jared: Let us gather together our people that we may number them, that we may know of them what they will desire of us before we go down to our graves.

20 Мөн тийн хүмүүс нэгдэн цуглуулагдав. Эдүгээ Жаредын ахын хөвгүүд болоод охидын тоо хорин хоёр бодгаль байв, мөн Жаредын хөвгүүд охидын тоо арван хоёр байв, тэрбээр дөрвөн хүүтэй байв.

21 Мөнхүү улиран тохиох дор тэд өөрсдийн хүмүүсийг тоолов; мөн тийн тэднийг тоолсныхоо дараа, тэд булшиндаа орохоос өмнө тэднийг юу хийгээсэй хэмээн хүсч буйг нь тэднээс асуув.

22 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс хөвгүүдийнхээ нэгийг тэдний дээр хаан байхаар тослогдохыг тэднээс хүсэв.

23 Мөн эдүгээ болгоогтун, энэ нь тэдэнд эмгэнэлтэй байв. Мөн Жаредын ах тэдэнд хандан хэлрүүн: Энэ зүйл боолчлолд гарцаагүй хөтлөх болно.

24 Гэвч Жаред ахдаа хандан хэлрүүн: Тэд хаантай байж болохыг тэдэнд зөвшөөрөгтүн. Мөн тиймийн тул тэрээр тэдэнд хэлсэн нь: Хөвгүүдийн маань дундаас бүр өөрсдийн хүссэнээ хаан болгон сонгогтун.

25 Мөнхүү улиран тохиох дор тэд бүр Жаредын ахын ууганыг нь сонгов; мөн түүний нэр Пегог байв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр татгалзаж мөн тэдний хаан болохгүй хэмээв. Мөн хүмүүс эцэг нь түүнийг албадаасай хэмээсэн аж, гэвч эцэг нь тэгэхээс татгалзав; мөн өөрсдийнхөө хаан болгох гэж тэд нэг ч хүмүүнийг албадах ёсгүйг тэрээр тэдэнд зарлиглав.

26 Мөнхүү улиран тохиох дор тэд Пегогийн бүх дүү нарыг сонгосон ч, мөн тэд тэгэхээс татгалзав.

27 Мөнхүү улиран тохиох дор Жаредын хөвгүүд ч бас, ганцаас бусад нь, бүр бүгд тэгэхээс татгалзсан буюу; мөн Ораиха хүмүүсийн дээр хаан нь байхаар тослогдсон ажгуу.

28 Мөн тэр засаглаж эхлэв, мөн хүмүүс дэгжиж эхлэв; мөн тэд үлэмж баян болцгоосон бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор Жаред, мөн түүний ах ч нас нөгчив.

30 Мөнхүү улиран тохиох дор Ораиха Их Эзэний өмнө даруухнаар алхаж байв, мөн Их Эзэн түүний эцгийнх нь төлөө ямар агуу зүйлүүд үйлдсэнийг санаж, мөн түүнчлэн Их Эзэн тэдний эцэг өвгөдийн төлөө ямар агуу зүйлүүд үйлдсэнийг өөрийн хүмүүст сургасан бөлгөө.

And accordingly the people were gathered together. Now the number of the sons and the daughters of the brother of Jared were twenty and two souls; and the number of sons and daughters of Jared were twelve, he having four sons.

And it came to pass that they did number their people; and after that they had numbered them, they did desire of them the things which they would that they should do before they went down to their graves.

And it came to pass that the people desired of them that they should anoint one of their sons to be a king over them.

And now behold, this was grievous unto them. And the brother of Jared said unto them: Surely this thing leadeth into captivity.

But Jared said unto his brother: Suffer them that they may have a king. And therefore he said unto them: Choose ye out from among our sons a king, even whom ye will.

And it came to pass that they chose even the firstborn of the brother of Jared; and his name was Pagag. And it came to pass that he refused and would not be their king. And the people would that his father should constrain him, but his father would not; and he commanded them that they should constrain no man to be their king.

And it came to pass that they chose all the brothers of Pagag, and they would not.

And it came to pass that neither would the sons of Jared, even all save it were one; and Orihah was anointed to be king over the people.

And he began to reign, and the people began to prosper; and they became exceedingly rich.

And it came to pass that Jared died, and his brother also.

And it came to pass that Orihah did walk humbly before the Lord, and did remember how great things the Lord had done for his father, and also taught his people how great things the Lord had done for their fathers.

## Ифер 7

- 1 Мөнхүү улиран тохиох дор Ораиха өөрийн бүх өдрүүдэд зөв шударга байдлаар нутгийн дээр хууль цаазыг хэрэгжүүлсэн бөлгөө, өдрүүд нь үлэмж олон байсан буюу.
- 2 Мөн тэрбээр хөвгүүд мөн охидтой болов; тийм ээ, тэрбээр гучин нэгийг төрүүлэв, тэдний дунд хорин гурав нь хөвгүүн байв.
- 3 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр өндөр насандаа Кибийг төрүүлэв. Мөнхүү улиран тохиох дор түүний сууринд Киб засаглав; мөн Киб Корихорыг төрүүлэв.
- 4 Мөн Корихор гучин хоёр насандаа тэрбээр эцгээ эсэргүүцэн босов, мөн явж Нихорын нутагт очиж суурьшив; мөн тэрбээр хөвгүүд мөн охидыг төрүүлж, мөн тэд үлэмж хонгорхон болов; иймийн тул Корихор олон хүмүүнийг араасаа дагуулсан болой.
- 5 Мөн тэрбээр их цэргийг нэгтгэн цуглуулаад, тэрбээр хааны суурьшиж асан Мороны нутагт ирж, мөн түүнийг олзлон авсан нь Жаредын ахын хэлсэн тэд боолчлолд хөтлөгдөх болно хэмээсэн үгийг улируулан тохиолгосон буюу.
- 6 Эдүгээ хааны суурьшиж асан Мороны нутаг нь Эзгүйрэл хэмээн нифайчуудаар нэрлэгдсэн нутгийн ойр байв.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Киб тэрбээр үлэмж өндөр насыг зооглох хүртлээ боолчлолд байж, мөн түүний хүмүүс түүний хүү Корихорын мэдэлд байв; гэсэн хэдий ч Киб өндөр насандаа, тэрбээр боолчлолд байх үедээ Шулег төрүүлэв.
- 8 Мөнхүү улиран тохиох дор Шуле ахдаа уурлаж байв, мөн Шуле хүч тэнхээтэй болж, мөн хүмүүний хүч чадлаар бол хүчит нэгэн болов; мөн тэрээр бас шүүн тунгаахдаа ч хүчит нэгэн байв.
- 9 Иймийн тул, тэрбээр Ефраимын гүвээн дээр ирэн, мөн тэрбээр гүвээнээс хайлуулан аваад, мөн өөрийн хамт дагуулсан тэдэнд зориулан гангаар илднүүд хийв; мөн тэднийг илдээр зэвсэглэснийхээ дараа тэрээр Нихор хотод эргэн ирж, мөн өөрийн ах Корихортой тулалдаанд орж, түүгээрээ тэрбээр хаант улсыг эзлэн авч мөн түүнийг эцэг Кибтээ сэргээн өгсөн бөлгөө.

## Ether 7

And it came to pass that Orihah did execute judgment upon the land in righteousness all his days, whose days were exceedingly many.

And he begat sons and daughters; yea, he begat thirty and one, among whom were twenty and three sons.

And it came to pass that he also begat Kib in his old age. And it came to pass that Kib reigned in his stead; and Kib begat Corihor.

And when Corihor was thirty and two years old he rebelled against his father, and went over and dwelt in the land of Nehor; and he begat sons and daughters, and they became exceedingly fair; wherefore Corihor drew away many people after him.

And when he had gathered together an army he came up unto the land of Moron where the king dwelt, and took him captive, which brought to pass the saying of the brother of Jared that they would be brought into captivity.

Now the land of Moron, where the king dwelt, was near the land which is called Desolation by the Nephites.

And it came to pass that Kib dwelt in captivity, and his people under Corihor his son, until he became exceedingly old; nevertheless Kib begat Shule in his old age, while he was yet in captivity.

And it came to pass that Shule was angry with his brother; and Shule waxed strong, and became mighty as to the strength of a man; and he was also mighty in judgment.

Wherefore, he came to the hill Ephraim, and he did molten out of the hill, and made swords out of steel for those whom he had drawn away with him; and after he had armed them with swords he returned to the city Nehor, and gave battle unto his brother Corihor, by which means he obtained the kingdom and restored it unto his father Kib.

10 Мөн эдүгээ Шулегийн хийсэн зүйлийн улмаас, түүний эцэг түүнд хаант улсаа өгөв; тиймийн тул тэрээр эцгийнхээ сууринд засаглаж эхлэв.

11 Мөнхүү улиран тохиох дор тэрээр зөв шударга байдлаар хууль цаазыг хэрэгжүүлсэн буюу; мөн хүмүүс үлэмж их тоотой болны учир тэрбээр хаант улсаа нутгийн бүх гадаргуу дээгүүр өргөжүүлэв.

12 Мөнхүү улиран тохиох дор Шуле түүнчлэн олон хөвгүүд охид төрүүлэв.

13 Мөн Корихор өөрийн үйлдсэн олон хилэнцэт үйлүүдээ наманчлав; иймийн тул Шуле хаант улсдаа түүнд хүчийг олгов.

14 Мөнхүү улиран тохиох дор Корихор олон хөвгүүд мөн охидтой байв. Мөн Корихорын хөвгүүдийн дунд Ноа хэмээх нэртэй нэгэн байв.

15 Мөнхүү улиран тохиох дор Ноа, Шуле хааны, мөн түүнчлэн өөрийн эцэг Корихорын эсрэг босож, мөн ах Кохорыгоо, мөн түүнчлэн өөрийн бүх ах дүүсийг мөн хүмүүсээс олныг дагуулав.

16 Мөн тэрбээр, хаан Шулегийн эсрэг тулаанд орж, тэгснээр тэдний анхных нь өвийн нутгийг эзэлж авав; мөн тэрбээр тэр нутгийн тэр хэсгийн дээр хаан болов.

17 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр, хаан Шулегийн эсрэг дахин тулалдаанд оров; мөн тэрбээр, хаан Шулег авч, мөн түүнийг Морон тийш олзлон аваачжээ.

18 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр түүнийг үхэлд хүргэх гэж байхад нь, Шулегийн хөвгүүд Ноагийн байшинд шөнөөр нэвтрэн орж мөн түүнийг хөнөөгөөд, мөн шоронгийн хаалгыг нураан мөн эцгээ гаргаж авав, мөн өөрийнх нь хаант улсын сэнтийд түүнийг залав.

19 Иймийн тул, Ноагийн хүү түүний оронд өөрийн хаант улсыг өргөтгөжээ; гэсэн хэдий ч тэд хаан Шулегийн дээр цаашид хүчийг олоогүй буюу, мөн хаан Шулегийн засаглалд байсан хүмүүс үлэмж дэгжиж мөн агуу болцгоов.

20 Мөнхүү гүрэн хуваагдав; мөн тэнд хоёр хаант улс, Шулегийн хаант улс, мөн Ноагийн хүү Кохорын хаант улс байх болов.

And now because of the thing which Shule had done, his father bestowed upon him the kingdom; therefore he began to reign in the stead of his father.

And it came to pass that he did execute judgment in righteousness; and he did spread his kingdom upon all the face of the land, for the people had become exceedingly numerous.

And it came to pass that Shule also begat many sons and daughters.

And Corihor repented of the many evils which he had done; wherefore Shule gave him power in his kingdom.

And it came to pass that Corihor had many sons and daughters. And among the sons of Corihor there was one whose name was Noah.

And it came to pass that Noah rebelled against Shule, the king, and also his father Corihor, and drew away Cohor his brother, and also all his brethren and many of the people.

And he gave battle unto Shule, the king, in which he did obtain the land of their first inheritance; and he became a king over that part of the land.

And it came to pass that he gave battle again unto Shule, the king; and he took Shule, the king, and carried him away captive into Moron.

And it came to pass as he was about to put him to death, the sons of Shule crept into the house of Noah by night and slew him, and broke down the door of the prison and brought out their father, and placed him upon his throne in his own kingdom.

Wherefore, the son of Noah did build up his kingdom in his stead; nevertheless they did not gain power any more over Shule the king, and the people who were under the reign of Shule the king did prosper exceedingly and wax great.

And the country was divided; and there were two kingdoms, the kingdom of Shule, and the kingdom of Cohor, the son of Noah.

- 21 Мөн Ноагийн хүү, Кохор өөрийн хүмүүсийг Шулегийн эсрэг тулаанд оруулж, тэгснээр Шуле тэднийг бут цохин мөн Кохорыг хөнөөв.
- 22 Мөн эдүгээ Кохор Нимрод хэмээн нэрлэгдсэн хүүтэй байв; мөн Нимрод Кохорын хаант улсыг Шулед өгөв, мөн тэрбээр Шулегийн нүдэнд тааллыг олов; иймийн тул Шуле түүнд агуу хайр хишиг хүртээж, мөн Шулегийн хаант улсад өөрийнхөө хүслээр тэр үйлдсэн буюу.
- 23 Мөн түүнчлэн Шулегийн засаглалд, хүмүүсийн дунд бошиглогчид ирэв, Их Эзэнээс илгээгдсэн тэд, хүмүүсийн ёс бусын үйл мөн хиймэл шүтээнийг шүтэх нь уг нутагт зүхлийг авчирч буй, мөн хэрэв тэд эс наманчлах аваас тэд устгагдах болно хэмээн бошиг-лосон ажээ.
- 24 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс бошиглогчдыг доромжлон, мөн тэднийг элэглэв. Мөнхүү улиран тохиох дор хаан Шуле бошиглогчдыг доромжилсон тэд бүгдийн эсрэг хууль цаазыг хэрэгжүүлсэн аж.
- 25 Мөн тэрбээр бүх газар нутгаар хуулийг хэрэг-жүүлсэн нь бошиглогчдод хаа хүссэн газраа явах хүчийг олгосон ажгуу; мөн энэ шалтгааны улмаас хүмүүс наманчлалд хүргэгдэв.
- 26 Мөн хүмүүс өөрсдийн алдсууд болоод хиймэл шүтээнүүдийг шүтэхээ наманчилсан учир Их Эзэн тэднийг хэлтрүүлж, мөн тэд уг нутагт дахин дэгжиж эхлэв. Мөнхүү улиран тохиох дор Шуле өндөр насандаа хөвгүүд мөн охидыг төрүүлэв.
- 27 Мөн Шулегийн өдрүүдэд дахин дайн байсангүй; мөн тэрбээр, амлагдсан газарт агуу гүнийг гаталган авчирснаар Их Эзэн эцэг өвгөдийнх нь төлөө хийсэн агуу зүйлийг санав; иймийн тул тэрбээр өөрийн бүх өдрүүдэд зөв шударга ёсоор хууль цаазыг хэрэг-жүүлсэн бөлгөө.

And Cohor, the son of Noah, caused that his people should give battle unto Shule, in which Shule did beat them and did slay Cohor.

And now Cohor had a son who was called Nimrod; and Nimrod gave up the kingdom of Cohor unto Shule, and he did gain favor in the eyes of Shule; wherefore Shule did bestow great favors upon him, and he did do in the kingdom of Shule according to his desires.

And also in the reign of Shule there came prophets among the people, who were sent from the Lord, prophesying that the wickedness and idolatry of the people was bringing a curse upon the land, and they should be destroyed if they did not repent.

And it came to pass that the people did revile against the prophets, and did mock them. And it came to pass that king Shule did execute judgment against all those who did revile against the prophets.

And he did execute a law throughout all the land, which gave power unto the prophets that they should go whithersoever they would; and by this cause the people were brought unto repentance.

And because the people did repent of their iniquities and idolatries the Lord did spare them, and they began to prosper again in the land. And it came to pass that Shule begat sons and daughters in his old age.

And there were no more wars in the days of Shule; and he remembered the great things that the Lord had done for his fathers in bringing them across the great deep into the promised land; wherefore he did execute judgment in righteousness all his days.



## Ифер 8

- 1 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Омерыг төрүүлж, мөн Омер түүний оронд засаглав. Мөн Омер Жаредыг төрүүлэв; мөн Жаред хөвгүүд болоод охидыг төрүүлэв.
- 2 Мөн Жаред эцгийнхээ эсрэг босч, мөн Хетийн нутагт ирж мөн суурьшив. Мөнхүү улиран тохиох дор тэрбээр хаант улсын хагасыг эзэгнэх хүртлээ, тэрбээр башир үгсийнхээ учир, олон хүнийг тэрбээр зусардав.
- 3 Мөн тэр хаант улсын хагасыг эзэгнээд эцгийнхээ эсрэг тэрээр тулалдаанд орж, мөн тэрээр эцгээ олзлон авч одов, мөн түүнийг боолчлолд үйлчлүүлэх болгов;
- 4 Мөн эдүгээ, Омерын засаглалын өдрүүдэд, өөрийн өдрүүдийн хагаст тэрээр боолчлолд байв. Мөнхүү улиран тохиох дор тэрбээр хөвгүүд мөн охидыг төрүүлж, тэдний дунд Изром мөн Кориантумр нар байв.
- 5 Мөн тэд өөрсдийн ах Жаредын үйлийн улмаас үлэмж хилэгнэн, үүний хэрээр тэд их цэрэг босгон мөн Жаредын эсрэг тулалдаанд оров. Мөнхүү улиран тохиох дор тэд түүний эсрэг шөнөөр тулалдаанд орсон ажээ.
- 6 Мөнхүү улиран тохиох дор тэд Жаредын их цэргийг хөнөөчихөөд түүнчлэн түүнийг ч хөнөөх гэж байв; мөн тэрбээр өөрийг нь үл хөнөөх аваас тэрбээр хаант улсаа эцэгтээ өгөх болно хэмээн тэднээс гуйв. Мөнхүү улиран тохиох дор тэд түүний амийг хэлтрүүлсэн ажгуу.
- 7 Мөн эдүгээ Жаред хаант улсынхаа алдагдлын улмаас, тэрбээр зүрх сэтгэлээ хаант улсдаа мөн дэлхийн алдар хүндэд байрлуулсны учир үлэмж харуусав.
- 8 Эдүгээ Жаредын охин үлэмж сэргэлэн зальтай, мөн эцгийнхээ харууслыг хараад, тэрбээр хаант улсыг эцэгтээ сэргээж өгөх төлөвлөгөө боловсруулахыг бодов.

## Ether 8

And it came to pass that he begat Omer, and Omer reigned in his stead. And Omer begat Jared; and Jared begat sons and daughters.

And Jared rebelled against his father, and came and dwelt in the land of Heth. And it came to pass that he did flatter many people, because of his cunning words, until he had gained the half of the kingdom.

And when he had gained the half of the kingdom he gave battle unto his father, and he did carry away his father into captivity, and did make him serve in captivity;

And now, in the days of the reign of Omer he was in captivity the half of his days. And it came to pass that he begat sons and daughters, among whom were Esrom and Coriantumr;

And they were exceedingly angry because of the doings of Jared their brother, insomuch that they did raise an army and gave battle unto Jared. And it came to pass that they did give battle unto him by night.

And it came to pass that when they had slain the army of Jared they were about to slay him also; and he pled with them that they would not slay him, and he would give up the kingdom unto his father. And it came to pass that they did grant unto him his life.

And now Jared became exceedingly sorrowful because of the loss of the kingdom, for he had set his heart upon the kingdom and upon the glory of the world.

Now the daughter of Jared being exceedingly expert, and seeing the sorrows of her father, thought to devise a plan whereby she could redeem the kingdom unto her father.

- 9 Эдүгээ Жаредын охин үлэмж хонгорхон байв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр эцэгтэйгээ ярьж, мөн түүнд хандан өгүүлсэн нь: Юунд эцэг минь ийм их харуусалтай байна вэ? Агуу гүнийг гатлан өвөг дээдсийн минь авчирсан цэдгийг тэрээр эс уншсан юм гэж үү? Болгоогтун, тэд өөрсдийн нууц төлөвлөгөөгөөр хаант улс хийгээд агуу алдар сууг эзэгнэсэн эртний тэдний талаар шастир үгүй гэж үү
- 10 Мөн эдүгээ, тиймийн тул, Кимнорын хүү Акишт эцэг минь илгээг; мөн болгоогтун, бибээр хонгорхон, мөн би түүний өмнө бүжиглэж, мөн би түүнийг баярлуулснаас тэрээр намайг эхнэрээ болгохыг хүсэх болно; иймийн тул хэрэв тэрээр танаас намайг түүнд эхнэр болгон өгөхийг хүсэх аваас, тэгвэл та түүнд хэлэгтүн: Хэрэв та миний эцэг, хааны толгойг надад авчрах аваас би түүнийг танд өгөх болно.
- 11 Мөн эдүгээ Омер Акишт анд нь байв; иймийн тул, Жаред Акишийг дуудаад, Жаредын охин түүний өмнө бүжиглэснээр түүнийг баярлуулж, чингээд тэрээр түүнийг эхнэрээ болгохыг хүсэв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр Жаредад хандан хэлсэн нь: Надад түүнийг эхнэр болгон өгөгтүн.
- 12 Мөн Жаред түүнд хандан: Хэрэв та надад миний эцэг, хааны толгойг авчирч өгөх аваас би түүнийг танд өгье хэмээн хэлжээ.
- 13 Мөнхүү улиран тохиох дор Акиш Жаредын гэрт түүний бүх төрлийнхнийг цуглуулан, мөн тэдэнд хэлсэн нь: Би та нараас хүсэх зүйлд та нар үнэнч байхаа надад андгайлах уу
- 14 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгдээрээ түүнд тэнгэрийн Бурханаар, мөн бас тэнгэрүүдээр, мөн түүнчлэн газар дэлхийгээр, мөн өөрсдийнхөө толгойгоор, хэн нэг нь Акишийн хүссэн тусламжийг үзүүлэхгүй аваас тэр толгойгоо алдана; мөн Акишийн тэдэнд мэдэгдсэн ямарваа зүйлийг илрүүлсэн хэн боловч, мөнхүү тэр нь амиа алдах болно хэмээн түүнд андгайлав.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тийн тэд Акиштай зөвшилцөв. Мөн Акиш эхлэлээс алуурчин байв бүр Каинаас доош гардагдсан тэр хүч чадлыг түүнчлэн эрэлхийлсэн эртний тэднээр өгөгдсөн тангаргийг тэднээр хэлүүлсэн ажгуу.

Now the daughter of Jared was exceedingly fair. And it came to pass that she did talk with her father, and said unto him: Whereby hath my father so much sorrow? Hath he not read the record which our fathers brought across the great deep? Behold, is there not an account concerning them of old, that they by their secret plans did obtain kingdoms and great glory?

And now, therefore, let my father send for Akish, the son of Kimnor; and behold, I am fair, and I will dance before him, and I will please him, that he will desire me to wife; wherefore if he shall desire of thee that ye shall give unto him me to wife, then shall ye say: I will give her if ye will bring unto me the head of my father, the king.

And now Omer was a friend to Akish; wherefore, when Jared had sent for Akish, the daughter of Jared danced before him that she pleased him, insomuch that he desired her to wife. And it came to pass that he said unto Jared: Give her unto me to wife.

And Jared said unto him: I will give her unto you, if ye will bring unto me the head of my father, the king.

And it came to pass that Akish gathered in unto the house of Jared all his kinsfolk, and said unto them: Will ye swear unto me that ye will be faithful unto me in the thing which I shall desire of you?

And it came to pass that they all sware unto him, by the God of heaven, and also by the heavens, and also by the earth, and by their heads, that whoso should vary from the assistance which Akish desired should lose his head; and whoso should divulge whatsoever thing Akish made known unto them, the same should lose his life.

And it came to pass that thus they did agree with Akish. And Akish did administer unto them the oaths which were given by them of old who also sought power, which had been handed down even from Cain, who was a murderer from the beginning.

16 Мөн эдгээр тангаргууд хүмүүст хэлэгдэхээр, тэднийг харанхуйд үлдээхийн тулд, хүчийг эрэлхийлэх түүнд хүчийг олж авахад, мөн хүн алахад, мөн тоноход, мөн худал хэлэхэд, мөн бүх л төрлийн ёсон бус үйлэнд мөн садар самууныг хийхэд туслахын тулд чөтгөрийн хүч чадлаар хадгалагдан үлдээгдсэн бөлгөө.

17 Мөн эртний эдгээр зүйлийг хайхыг түүний зүрх сэтгэлд суулгасан тэр бол Жаредын охин байв; мөн Жаред үүнийг Акишийн зүрх сэтгэлд суулгасан ажээ; иймийн тул, Акиш үүнийг түүний төрөл мөн нөхдөөр хэлүүлж, өөрийн хүссэн бүх зүйлийг хийхээр дур булаам амлалтаар тэднийг удирдан дагуулжээ.

18 Мөнхүү улиран тохиох дор тэд яг л эртнийх лугаа адил, нууц хуйвалдааныг, Бурханы мэлмийд хамгийн жигшүүрт мөн ёс бус болох хуйвалдааныг бий болго.

19 Учир нь Их Эзэн нууц хуйвалдаанаар ажиллах нь үгүй, бас хүмүүн цусаа урсгахыг тэр таалах нь үгүй, харин бүх зүйл дээр түүнийг хүмүүний эхлэлээс хориглосон билээ.

20 Мөн эдүгээ би, Моронай, тэдний тангаргийн мөн хуйвалдаануудын аргыг эс бичнэм, учир нь тэдгээр нь бүх хүмүүсийн дунд байдаг, мөн тэдгээр нь леменчүүдийн дунд байгаа нь надад мэдүүлэгдсэн болой.

21 Мөн тэдгээр нь миний одоо тухайлан ярьж буй эдгээр хүмүүсийн устгалын, мөн түүнчлэн Нифайн хүмүүсийн устгалын шалтгаан болсон юм.

22 Мөн хүчийг олж мөн хөрөнгө хураахаар, нууц хуйвалдаанууд тэр үндэстнийг эзэгнэх болтол тэдгээрийг дэмжих ямарваа үндэстэн, болгоогтун, тэд устгагдах болно; учир нь тэдний урсгах өөрийнх нь гэгээнтнүүдийн цус нь тэднээс өс хонзон авахуулахаар газраас өөрт нь хандан үргэлж гуйхыг мөн өөрөө өс хонзонг тэднээс авахгүй байхыг Их Эзэн хүлцэх бөлгөө.

And they were kept up by the power of the devil to administer these oaths unto the people, to keep them in darkness, to help such as sought power to gain power, and to murder, and to plunder, and to lie, and to commit all manner of wickedness and whoredoms.

And it was the daughter of Jared who put it into his heart to search up these things of old; and Jared put it into the heart of Akish; wherefore, Akish administered it unto his kindred and friends, leading them away by fair promises to do whatsoever thing he desired.

And it came to pass that they formed a secret combination, even as they of old; which combination is most abominable and wicked above all, in the sight of God;

For the Lord worketh not in secret combinations, neither doth he will that man should shed blood, but in all things hath forbidden it, from the beginning of man.

And now I, Moroni, do not write the manner of their oaths and combinations, for it hath been made known unto me that they are had among all people, and they are had among the Lamanites.

And they have caused the destruction of this people of whom I am now speaking, and also the destruction of the people of Nephi.

And whatsoever nation shall uphold such secret combinations, to get power and gain, until they shall spread over the nation, behold, they shall be destroyed; for the Lord will not suffer that the blood of his saints, which shall be shed by them, shall always cry unto him from the ground for vengeance upon them and yet he avenge them not.

23 Иймийн тул, эдгээр зүйлүүд та нарт үзүүлэгдэх нь Бурханы мэргэн ухаан Ай харийнхан та нар, тэгснээр та нар нүглээ наманчилж, мөн хүчийг олж мөн хөрөнгө хураахын тулд байгуулагдсан эдгээр аллагын хуйвалдаанууд өөрсдийн тань дээр давж гарыг—мөн уг ажил, тийм ээ, бүр устгалын ажил өөрсдийн дээр чинь ирэхийг зөвшөөрөхгүй байж болно, тийм ээ, хэрэв та нар эдгээр зүйлүүдийг оршихыг зөвшөөрөх аваас, та нарын уналт мөн устгалд хүргэх, бүр Мөнхийн Бурханы шударга ёсны илд та нарын дээр буух болно.

24 Иймийн тул, та нарын дунд эдгээр зүйлүүд ирэхийг та нар үзэх үед, та нарын дунд орших энэ нууц хуйвалдааны улмаас, өөрсдийн аймшигт байдлынхаа мэдрэмжинд та нар сэрэгтүн хэмээн Их Эзэн та нарт зарлиг болгосон билээ; эс бөгөөс алагдсан тэдний цусны улмаас, үүнд халаг болог; учир нь тэд үүний дээр, мөн түүнчлэн үүнийг бий болгосон тэдний дээр өс хонзон авалт ирүүлэхийн тул газар шорооноос гуйх буюу.

25 Учир нь улиран тохиох дор үүнийг бий болгох хэн боловч бүх нутгуудын, үндэстнүүдийн, мөн улсуудын эрх чөлөөг булаан авахаар эрэлхийлдэг мөн энэ нь бүх хүмүүсийн устгалыг улируулан тохиолгодог, учир нь энэ нь бүх худал хуурмагийн эцэг; бүр бидний анхны эцэг эхийг хуурсан тэрхүү худалч, тийм ээ, бүр эхлэлээс эхлэн хүмүүнийг аллага үйлдэх болгосон; тэд бошиглогчдыг алан, мөн тэднийг чулуугаар шидсэн, мөн эхлэлээс эхлэн тэднийг хөөн гаргах болгож хүмүүсийн зүрх сэтгэлийг хатууруулсан мөнхүү тэр худалч болох чөтгөрөөр бий болгогдсон юм.

26 Иймийн тул, хилэнцэт үйл зогсоогдож болох, мөн хүмүүний үрсийн зүрх сэтгэлд Сатан ямар ч хүчийг агуулж үл чадах, харин тэд үргэлжлүүлэн сайныг хийхээр ятгагдаж болох, тэд бүх л зөв шударгын эх булагт ирж мөн аврагдаж болох тэр цаг ирж болохын тулд би, Моронай, эдгээр зүйлүүдийг бичихээр зарлиг болгогдсон билээ.

Wherefore, O ye Gentiles, it is wisdom in God that these things should be shown unto you, that thereby ye may repent of your sins, and suffer not that these murderous combinations shall get above you, which are built up to get power and gain—and the work, yea, even the work of destruction come upon you, yea, even the sword of the justice of the Eternal God shall fall upon you, to your overthrow and destruction if ye shall suffer these things to be.

Wherefore, the Lord commandeth you, when ye shall see these things come among you that ye shall awake to a sense of your awful situation, because of this secret combination which shall be among you; or wo be unto it, because of the blood of them who have been slain; for they cry from the dust for vengeance upon it, and also upon those who built it up.

For it cometh to pass that whoso buildeth it up seeketh to overthrow the freedom of all lands, nations, and countries; and it bringeth to pass the destruction of all people, for it is built up by the devil, who is the father of all lies; even that same liar who beguiled our first parents, yea, even that same liar who hath caused man to commit murder from the beginning; who hath hardened the hearts of men that they have murdered the prophets, and stoned them, and cast them out from the beginning.

Wherefore, I, Moroni, am commanded to write these things that evil may be done away, and that the time may come that Satan may have no power upon the hearts of the children of men, but that they may be persuaded to do good continually, that they may come unto the fountain of all righteousness and be saved.

## Ифер 9

- 1 Мөн эдүгээ, би, Моронай, цэдгээ үргэлжлүүлэе. Тиймийн тул, болгоогтун, мөнхүү улиран тохиох дор Акиш мөн түүний найзуудын нууц хуйвалдаануудын улмаас, болгоогтун, тэд Омерын хаант улсыг булаан авав.
- 2 Гэсэн хэдий ч, Их Эзэн Омерт нигүүлсэнгүй байв, мөн түүнчлэн түүний, хөвгүүд хийгээд охидынх нь устгалыг эрэлхийлсэнгүй.
- 3 Мөн Омерт зүүдэнд нь уг нутгаас гарч одохыг Их Эзэн сэрэмжлүүлэв; иймийн тул Омер гэр бүлийнхээ хамт нутгаас гарч одон, мөн олон өдөр аялж, мөн Шимийн толгойд ирэн мөн хажуугаар нь өнгөрч, мөн нифайчуудын устгагдсан тэр газрын ойролцоо ирэв, мөн тэндээс зүүн тийш, мөн тэнгисийн эргийн дагуух, Аблом гэж нэрлэгдэх газар ирэв, мөн тэрээр тэнд майхнаа босгов, мөн түүнчлэн Жаред болон түүний гэр бүлээс бусад, түүний хөвгүүд мөн охид нь, мөн түүний бүх гэрийнхэн нь буюу.
- 4 Мөнхүү улиран тохиох дор Жаред хүмүүсийн дээр, ёс бусын гараар тослогдсон хаан болов; мөн тэр Акишт охиноо эхнэр болгон өгөв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Акиш хадам эцгийнхээ амийг эрэлхийлэв; мөн тэрээр эртнийхний тангаргаар андгайлсан тэдэндээ хандав; мөн тэд, тэрээр хаан ширээнээ заларч, өөрийн хүмүүсийг хүлээн авч байхад нь хадам эцгийнх нь толгойг авав.
- 6 Учир нь, энэхүү ёс бус мөн нууц нийгэмлэгийн тархалт бүх хүмүүсийн зүрх сэтгэлийг эзлэх болтлоо тийм агуу байлаа; тиймийн тул Жаред хаан ширээн дээ алагдан, мөн Акиш түүний оронд засаглав.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Акиш хүүдээ атаархаж эхлэн, тиймийн тул тэрээр түүнийг шоронд хорин, мөн түүнийг өчүүхэн хоолтойгоор эсвэл огт хоолгүйгээр үхэлтэй учрах хүртэл нь тэрээр үлдээсэн ажгуу.
- 8 Мөн эдүгээ үхэлтэй учирсан түүний дүү (түүний нэр Нимра байв) эцгийнх нь ахад нь хийсэн тэр зүйлийн улмаас эцэгтээ хилэгнэж байв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор Нимра цөөн тооны эрчүүдийг цуглуулан, мөн уг нутгаас дайжив, мөн ирж тэгээд Омертой хамт суурьшив.

## Ether 9

And now I, Moroni, proceed with my record. Therefore, behold, it came to pass that because of the secret combinations of Akish and his friends, behold, they did overthrow the kingdom of Omer.

Nevertheless, the Lord was merciful unto Omer, and also to his sons and to his daughters who did not seek his destruction.

And the Lord warned Omer in a dream that he should depart out of the land; wherefore Omer departed out of the land with his family, and traveled many days, and came over and passed by the hill of Shim, and came over by the place where the Nephites were destroyed, and from thence eastward, and came to a place which was called Ablom, by the seashore, and there he pitched his tent, and also his sons and his daughters, and all his household, save it were Jared and his family.

And it came to pass that Jared was anointed king over the people, by the hand of wickedness; and he gave unto Akish his daughter to wife.

And it came to pass that Akish sought the life of his father-in-law; and he applied unto those whom he had sworn by the oath of the ancients, and they obtained the head of his father-in-law, as he sat upon his throne, giving audience to his people.

For so great had been the spreading of this wicked and secret society that it had corrupted the hearts of all the people; therefore Jared was murdered upon his throne, and Akish reigned in his stead.

And it came to pass that Akish began to be jealous of his son, therefore he shut him up in prison, and kept him upon little or no food until he had suffered death.

And now the brother of him that suffered death, (and his name was Nimrah) was angry with his father because of that which his father had done unto his brother.

And it came to pass that Nimrah gathered together a small number of men, and fled out of the land, and came over and dwelt with Omer.

10 Мөнхүү улиран тохиох дор Акиш өөр бусад хөвгүүдийг төрүүлэв, мөн хэдийгээр тэд хүссэний дагуу бүх л төрлийн алдсыг хийхээр түүнд андгайлсан тэр хүмүүсийн зүрх сэтгэлийг татжээ.

11 Эдүгээ Акиш хүч чадлыг олохыг хүсдэг байсан лугаа адил, Акишийн хүмүүс хөрөнгө олохыг хүсдэг байв; иймийн тул, Акишийн хөвгүүд тэдэнд мөнгө өгөхөөр болов, үүгээрээ тэд хүмүүсийн ихээхэн хэсгийг араасаа дагуулав.

12 Мөн Акишийн хөвгүүд болон Акишийн хооронд, тийм ээ, хаант улсын бараг бүх хүмүүсийн тийм ээ, гучин бодгалиас, мөн Омерын угсаатай хамт дүрвэсэн тэднээс бусад бүгдийг устгалд хүргэсэн олон жилийн туршид үргэлжилсэн дайн эхлэв.

13 Иймийн тул, Омер өвийн нутагтаа дахин сэргээгдэв.

14 Мөнхүү улиран тохиох дор Омер нас өндөр болж эхлэв; гэсэн хэдий ч, өндөр насандаа тэрээр Имерийг төрүүлэв; мөн тэрээр Имерийг өөрийн оронд засаглах хаан байхаар тослов.

15 Мөн тэрээр Имерийг хаан болгохоор авшиг хүртээснийхээ дараа, тэрээр хоёр жилийн туршид уг нутагт амар амгаланг тэрээр үзэв, мөн гашуудлаар дүүрэн байсан үлэмж олон өдрийг үзжээ мөн тэрээр нас нөгчив. Мөнхүү улиран тохиох дор Имер түүний оронд засаглаж, мөн эцгийнхээ мөрөөр замнасан буюу.

16 Мөн Их Эзэн уг нутгаас зүхлийг дахин холдуулж эхлэв, мөн Имерийн үр удам Имэрийн засаглалын дор үлэмж дэгжив; мөн жаран хоёр жилийн дотор тэд үлэмж хүчирхэг болж, үүний хэрээр тэд үлэмж баян болцгоов—

17 Бүх л төрлийн жимс, мөн үр тариа, мөн торго, мөн нарийн нэхээст эд, мөн алт, мөн мөнгө, мөн үнэт зүйлстэй байв;

18 Мөн түүнчлэн бүх төрлийн мал, шар, мөн үнээ, мөн хонь, мөн гахай, мөн ямаа, мөн түүнчлэн хүмүүний хоол хүнсэнд тустай бусад олон төрлийн амьтадтай байв.

19 Мөн тэд түүнчлэн морь, мөн илжигтэй байв, мөн заан мөн кюрулом мөн күмомуудтай байв; энэ бүгд нь, мөн ялангуяа заан мөн кюрулом мөн күмом нь хүмүүнд тустай байсан бөлгөө.

And it came to pass that Akish begat other sons, and they won the hearts of the people, notwithstanding they had sworn unto him to do all manner of iniquity according to that which he desired.

Now the people of Akish were desirous for gain, even as Akish was desirous for power; wherefore, the sons of Akish did offer them money, by which means they drew away the more part of the people after them.

And there began to be a war between the sons of Akish and Akish, which lasted for the space of many years, yea, unto the destruction of nearly all the people of the kingdom, yea, even all, save it were thirty souls, and they who fled with the house of Omer.

Wherefore, Omer was restored again to the land of his inheritance.

And it came to pass that Omer began to be old; nevertheless, in his old age he begat Emer; and he anointed Emer to be king to reign in his stead.

And after that he had anointed Emer to be king he saw peace in the land for the space of two years, and he died, having seen exceedingly many days, which were full of sorrow. And it came to pass that Emer did reign in his stead, and did fill the steps of his father.

And the Lord began again to take the curse from off the land, and the house of Emer did prosper exceedingly under the reign of Emer; and in the space of sixty and two years they had become exceedingly strong, in-somuch that they became exceedingly rich—

Having all manner of fruit, and of grain, and of silks, and of fine linen, and of gold, and of silver, and of precious things;

And also all manner of cattle, of oxen, and cows, and of sheep, and of swine, and of goats, and also many other kinds of animals which were useful for the food of man.

And they also had horses, and asses, and there were elephants and cureloms and cumoms; all of which were useful unto man, and more especially the elephants and cureloms and cumoms.

- 20 Мөн тийн Их Эзэн бусад бүх нутгаас дээгүүр сонгомол асан энэ нутагт адислалуудаа цутгав; мөн уг нутгийг эзэмших хэн боловч үүнийг Их Эзэний төлөө эзэмшихийг тэрээр зарлиг болсон ажээ, эс бөгөөс алдастаа бүрнээ боловсорсон үед тэд устгагдах болно; учир нь ингэх тэдний дээр: Би уур хилэнгээ бүрнээр нь цутгах болно хэмээн Их Эзэн хэлсэн ажээ.
- 21 Мөн Имер өөрийн бүх өдөртөө, зөв шударгаар хууль цаазыг хэрэгжүүлж, мөн тэрээр олон хөвгүүд мөн охидыг төрүүлэв; мөн тэрээр Кориантумыг төрүүлж, мөн Кориантумыг өөрийн оронд засаглуулахаар тослов.
- 22 Мөн тэрээр өөрийн оронд засаглуулахаар Кориантумыг тосолсны дараа тэрээр дөрвөн жил амьдарсан ажгуу, мөн тэрээр уг нутагт амар амгалант үзэв; тийм ээ, мөн тэрээр бүр Зөв Шударгын Хүүг харав, мөн түүний өдөрт баясаж мөн бахархав; мөн тэрээр амар амгаланд нас нөгчив.
- 23 Мөнхүү улиран тохиох дор Кориантум эцгийнхээ мөрөөр замнаж, мөн олон хүчирхэг хот барьж, мөн өөрийн бүх өдрүүддээ өөрийн хүмүүст сайн болох түүнийг гүйцэтгэсэн буюу. Мөнхүү улиран тохиох дор тэрээр бүр нас үлэмж өндөр болох хүртлээ үр хүүхэдгүй байжээ.
- 24 Мөнхүү улиран тохиох дор түүний эхнэр, зуун хоёр насыг зооглон, өөд болов. Мөнхүү улиран тохиох дор Кориантум өндөр насандаа, залуу бүсгүйг эхнэр болгон авч, мөн хөвгүүд болоод охидыг төрүүлэв; иймийн тул тэрээр зуун дөчин хоёр нас хүртлээ амьдарсан бөлгөө.
- 25 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Комыг төрүүлж, мөн Ком түүний оронд засаглав; мөн тэрээр дөчин есөн жил засаглаж, мөн тэр Хэтийг төрүүлэв; мөн тэр түүнчлэн бусад хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв.
- 26 Мөнхүү хүмүүс дахин нутгийн бүх гадаргуу дээр тархсан байв, мөн уг нутгийн гадаргуу дээр дахин үлэмж агуу ёс бусын үйл бий болж эхлэв, мөн Хет өөрийн эцгийг устгахаар эртний нууц төлөвлөгөөнүүдийг дахин өөгшүүлэн дэмжиж эхлэв.

And thus the Lord did pour out his blessings upon this land, which was choice above all other lands; and he commanded that whoso should possess the land should possess it unto the Lord, or they should be destroyed when they were ripened in iniquity; for upon such, saith the Lord: I will pour out the fulness of my wrath.

And Emer did execute judgment in righteousness all his days, and he begat many sons and daughters; and he begat Coriantum, and he anointed Coriantum to reign in his stead.

And after he had anointed Coriantum to reign in his stead he lived four years, and he saw peace in the land; yea, and he even saw the Son of Righteousness, and did rejoice and glory in his day; and he died in peace.

And it came to pass that Coriantum did walk in the steps of his father, and did build many mighty cities, and did administer that which was good unto his people in all his days. And it came to pass that he had no children even until he was exceedingly old.

And it came to pass that his wife died, being an hundred and two years old. And it came to pass that Coriantum took to wife, in his old age, a young maid, and begat sons and daughters; wherefore he lived until he was an hundred and forty and two years old.

And it came to pass that he begat Com, and Com reigned in his stead; and he reigned forty and nine years, and he begat Heth; and he also begat other sons and daughters.

And the people had spread again over all the face of the land, and there began again to be an exceedingly great wickedness upon the face of the land, and Heth began to embrace the secret plans again of old, to destroy his father.

27 Мөнхүү улиран тохиох дор тэрээр эцгээ хаан ширээнээс нь унагав, учир нь тэрбээр түүнийг өөрийнх нь илдээр хөнөөсөн ажгуу; мөн тэрээр түүний оронд засаглав.

28 Мөн бошиглогчид, тэдэнд наманчлалыг тунхагласаар уг хутагт дахин ирэв—тэд Их Эзэний замыг бэлтгэх ёстой эсвээс уг нутгийн гадаргуу дээр зүхэл ирэх болно; тийм ээ, хэрэв тэд эс наманчлах аваас бүр агуу өлсгөлөн болж тэд түүгээр устгагдах болно гэв.

29 Гэвч хүмүүс бошиглогчдын үгэнд итгэсэнгүй, харин тэд тэднийг хөөн зайлуулав; мөн тэдний заримыг нь нүхэнд хаян мөн тэднийг эрсдүүлэхээр орхив. Мөнхүү улиран тохиох дор тэд эдгээр бүх зүйлийг хаан Хетийн зарлигийн дагуу үйлджээ.

30 Мөнхүү улиран тохиох дор уг нутагт агуу өлөн зэлмүүн байж эхлэв, мөн газрын гадаргуу дээр хур бороо эс орсны учир, оршин суугчид нь өлөн зэлмүүнээс болон үтэр түргэнээр устгагдаж эхлэв.

31 Мөн нутгийн гадаргуу дээр түүнчлэн хорт могойнууд гарч ирж, мөн олон хүмүүнийг хордуулсан аж. Мөнхүү улиран тохиох дор тэдний мал хорт могойнуудын өмнө, нифайчуудаар Зарахемла хэмээн нэрлэгдсэн өмнөд нутаг тийш дайжиж эхлэв.

32 Мөнхүү улиран тохиох дор тэдний олон нь замдаа эрсэдсэн ажээ; гэсэн хэдий ч, өмнө зүгийн нутагт дайжиж хүрсэн зарим нь байв.

33 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн могойнууд тэднийг цааш үлдэн хөөхгүй болгон, харин өнгөрч гарах гэсэн хэн бүхэн хорт могойнуудад хөнөөгдөн унаж болохын тулд хүмүүс өнгөрөн гарч чадахааргүйгээр могойнуудаар замыг нь хаах болгосон ажээ.

34 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс амьтдын жимийг даган, мөн замаар унасан тэдний сэгийг, тэд бүгдийг нь идэж дуусгах хүртэл, ховдоглон идэв. Эдүгээ хүмүүс эрсдэх учиртайгаа үзээд тэд алдсаа наманчилж мөн Их Эзэнд залбиран гуйж эхлэв.

And it came to pass that he did dethrone his father, for he slew him with his own sword; and he did reign in his stead.

And there came prophets in the land again, crying repentance unto them—that they must prepare the way of the Lord or there should come a curse upon the face of the land; yea, even there should be a great famine, in which they should be destroyed if they did not repent.

But the people believed not the words of the prophets, but they cast them out; and some of them they cast into pits and left them to perish. And it came to pass that they did all these things according to the commandment of the king, Heth.

And it came to pass that there began to be a great dearth upon the land, and the inhabitants began to be destroyed exceedingly fast because of the dearth, for there was no rain upon the face of the earth.

And there came forth poisonous serpents also upon the face of the land, and did poison many people. And it came to pass that their flocks began to flee before the poisonous serpents, towards the land southward, which was called by the Nephites Zarahemla.

And it came to pass that there were many of them which did perish by the way; nevertheless, there were some which fled into the land southward.

And it came to pass that the Lord did cause the serpents that they should pursue them no more, but that they should hedge up the way that the people could not pass, that whoso should attempt to pass might fall by the poisonous serpents.

And it came to pass that the people did follow the course of the beasts, and did devour the carcasses of them which fell by the way, until they had devoured them all. Now when the people saw that they must perish they began to repent of their iniquities and cry unto the Lord.



35 Мөнхүү улиран тохиох дор тэд Их Эзэний өмнө өөрсдийгөө хангалттайгаар даруусгасны нь дараа тэр газрын гадаргуу дээр хур илгээв; мөн хүмүүс дахин тэнхэрч эхлэн, мөн умард зүгийн нутгуудад, мөн бүх эргэн тойрны нутгуудад жимс байж эхлэв. Мөнхүү Их Эзэн тэднийг өлсгөлөнгөөс хамгаалснаар тэдэнд хүчээ үзүүлсэн буюу.

And it came to pass that when they had humbled themselves sufficiently before the Lord he did send rain upon the face of the earth; and the people began to revive again, and there began to be fruit in the north countries, and in all the countries round about. And the Lord did show forth his power unto them in preserving them from famine.

## Ифер 10

- 1 Мөнхүү улиран тохиох дор Хетийн удам асан, Шез—Хет, мөн Шезээс бусад түүний бүх гэрийнхэн, өлсгөлөнгөөр үрэгдсэн учир—иймийн тул, Шез бутарсан хүмүүсээ дахин нэгтгэж эхлэв.
- 2 Мөнхүү улиран тохиох дор Шез эцэг өвгөдийнхөө устгалыг санаж байв, мөн тэрээр зөв шударга хаант улсыг байгуулав; учир нь Их Эзэн Жаред мөн түүний ахыг гүнийг гатлуулан авчрахад юу хийснийг тэрбээр санаж байв; мөн тэрбээр Их Эзэний замаар алхаж байлаа; мөн тэр хөвгүүд болон охидыг төрүүлсэн бөлгөө.
- 3 Мөн түүний, Шез хэмээх нэртэй асан, ууган хүү нь түүний эсрэг босов; гэсэн хэдий ч, Шез, үлэмж баялгийнхаа улмаас, дээрэмчний гараар бут цохигдсоноос, ийн эцэгт нь ахин амар амгалан авчрагдав.
- 4 Мөнхүү улиран тохиох дор түүний эцэг нутгийн гадаргуу дээр олон хот босгож, мөн хүмүүс дахин нутгийн бүх гадаргуу дээгүүр тархаж эхлэв. Мөн Шез үлэмж өндөр нас хүрч амьдрал; мөн тэрээр Рипликишийг төрүүлэв. Мөн тэрээр нас нөгчиж, тэгээд Рипликиш түүний оронд засаглав.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэний мэлмийд зөв болох түүнийг Рипликиш эс үйлдэв, учир нь тэр олон эхнэр мөн татвар эмстэй байв, мөн үүрэхэд хүнд байсан түүнийг хүмүүсийн мөрөн дээр тавьсан ажээ; тийм ээ, тэрбээр тэднээс хүнд татвар татаж байв; мөн татвараар тэрээр олон сэлүүхэн барилгуудыг барьжээ.
- 6 Мөн тэрээр үлэмж үзэсгэлэнт хаан ширээг өөртөө босгов, мөн тэрээр олон шорон барьж, мөн татварт үл харъяалагдах гэсэн хэн бүхнийг тэрээр шоронд хаяж байлаа; мөн татвараа төлөх чадваргүй хэн бүхнийг тэрээр шоронд хаяж байв; мөн тэрээр тэд өөрсдийгөө тэтгэхийн тулд үргэлж хөдөлмөрлөх болгосон аж; мөн хөдөлмөрлөхөөс татгалзсан хэн бүхнийг тэрээр үхэлд хүргэгдэхээр болгосон ажгуу.

## Ether 10

And it came to pass that Shez, who was a descendant of Heth—for Heth had perished by the famine, and all his household save it were Shez—wherefore, Shez began to build up again a broken people.

And it came to pass that Shez did remember the destruction of his fathers, and he did build up a righteous kingdom; for he remembered what the Lord had done in bringing Jared and his brother across the deep; and he did walk in the ways of the Lord; and he begat sons and daughters.

And his eldest son, whose name was Shez, did rebel against him; nevertheless, Shez was smitten by the hand of a robber, because of his exceeding riches, which brought peace again unto his father.

And it came to pass that his father did build up many cities upon the face of the land, and the people began again to spread over all the face of the land. And Shez did live to an exceedingly old age; and he begat Riplakish. And he died, and Riplakish reigned in his stead.

And it came to pass that Riplakish did not do that which was right in the sight of the Lord, for he did have many wives and concubines, and did lay that upon men's shoulders which was grievous to be borne; yea, he did tax them with heavy taxes; and with the taxes he did build many spacious buildings.

And he did erect him an exceedingly beautiful throne; and he did build many prisons, and whoso would not be subject unto taxes he did cast into prison; and whoso was not able to pay taxes he did cast into prison; and he did cause that they should labor continually for their support; and whoso refused to labor he did cause to be put to death.

- 7 Иймийн тул тэрээр өөрийн бүх сайн бүтээлийг олж авсан аж, тийм ээ, өөрийн шижир алтыг тэрээр шоронд цэвэршүүлэх болгов; мөн бүх л төрлийн уран сайн хийцүүдийг тэрээр шоронд бүтээлгэ гэдэг байв. Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүсийг өөрийн садар самуун мөн жигшүүрт хэргүүдээрээ зовоож шаналгасан аж.
- 8 Мөн тэрээр дөчин хоёр жилийн туршид засаглахад хүмүүс түүний эсрэг бослого гаргав; мөн нутаг дахин дайн эхлэв, үүний хэрээр Рипликиш алагдаж, мөн түүний үр удам уг нутгаас хөөгджээ.
- 9 Мөнхүү улиран тохиох дор олон жилийн дараа, Мориантон, (тэрээр Рипликишийн удам байв) гадуурхагдагсдаас их цэргийг цуглуулан бүрдүүлж, мөн давшин явж мөн хүмүүстэй тулалдаанд оров; мөн тэрээр олон хотын дээр хүчийг олсон болой; мөн дайн үлэмж ноцтой болж, мөн олон жилийн туршид үргэлжлэв; мөн тэрээр бүх нутгийн дээр хүчийг олж, мөн бүх нутгийн дээр өөрийгөө хаанаар өргөмжлөв.
- 10 Мөн өөрийгөө тэрээр хаанаар өргөмжилсний дараа тэрбээр хүмүүсийн ачаа үүргийг хөнгөлж, тэгснээрээ хүмүүсийн нүдэнд тааллыг олжээ, мөн тэд түүнийг хаанаа байхаар тослон адислав.
- 11 Мөн тэрээр хүмүүст шударгаар үйлдэж байв, гэвч өөрийн олон садар самууны улмаас өөртөө эс бөлгөө; иймийн тул тэрээр Их Эзэний дэргэдээс тусгаарлагдсан ажгуу.
- 12 Мөнхүү улиран тохиох дор Мориантон олон хот босгож, мөн хүмүүс түүний засаглалын дор барилгаар, мөн алт болон мөнгөөр, мөн үр тариа ургуулснаар, мөн бог болон бод мал, мөн тэдэнд сэргээгдсэн тийм зүйлүүдээр үлэмж баян болов.
- 13 Мөн Мориантон үлэмж агуу насыг зооглон амьдарч, тэгээд тэр Кимийг төрүүлэв; мөн Ким эцгийнхээ оронд засаглав; мөн тэрээр найман жил засаглаж, мөн эцэг нь нас нөгчिव. Мөнхүү улиран тохиох дор Ким зөв шударгад эс засаглаж, иймийн тул тэрээр Их Эзэний ээл хишгийг үл хүртсэн ажгуу.

Wherefore he did obtain all his fine work, yea, even his fine gold he did cause to be refined in prison; and all manner of fine workmanship he did cause to be wrought in prison. And it came to pass that he did afflict the people with his whoredoms and abominations.

And when he had reigned for the space of forty and two years the people did rise up in rebellion against him; and there began to be war again in the land, inso-much that Riplakish was killed, and his descendants were driven out of the land.

And it came to pass after the space of many years, Morianton, (he being a descendant of Riplakish) gathered together an army of outcasts, and went forth and gave battle unto the people; and he gained power over many cities; and the war became exceedingly sore, and did last for the space of many years; and he did gain power over all the land, and did establish himself king over all the land.

And after that he had established himself king he did ease the burden of the people, by which he did gain favor in the eyes of the people, and they did anoint him to be their king.

And he did do justice unto the people, but not unto himself because of his many whoredoms; wherefore he was cut off from the presence of the Lord.

And it came to pass that Morianton built up many cities, and the people became exceedingly rich under his reign, both in buildings, and in gold and silver, and in raising grain, and in flocks, and herds, and such things which had been restored unto them.

And Morianton did live to an exceedingly great age, and then he begat Kim; and Kim did reign in the stead of his father; and he did reign eight years, and his father died. And it came to pass that Kim did not reign in righteousness, wherefore he was not favored of the Lord.

14 Мөн түүний дүү нь түүний эсрэг бослого гаргаж, тэгснээрээ түүнийг боолчлолд авчрав; мөн тэрээр амьдралынхаа бүх өдрүүдэд боолчлолд үлдсэн болой; мөн тэрээр боолчлолд хөвгүүд мөн охидыг төрүүлж, мөн өндөр насандаа тэрээр Ливайг төрүүлэв; мөн тэрээр нас нөгчив.

15 Мөнхүү улиран тохиох дор, Ливай эцгээ нас нөгчсөнөөс хойш дөчин хоёр жилийн турш боолчлолд үйлчлэв. Мөн тэрээр уг нутгийн хааны эсрэг дайн хийж, тэгснээр тэрээр хаант улсыг өөртөө авав.

16 Мөн хаант улсыг тэрээр өөртөө авсны дараа тэрээр Их Эзэний мэлмийд зөв болох түүнийг үйлдэв; мөн хүмүүс нутагт дэгжив; мөн тэрээр их өндөр нас зооглон амьдарч, мөн хөвгүүд хийгээд охидыг төрүүлэв; мөн тэрээр Коромыг төрүүлж, түүнийг тэрээр өөрийн оронд хаан болгон тослон адисалжээ.

17 Мөнхүү улиран тохиох дор Кором өөрийн бүх өдрүүдэд Их Эзэний мэлмийд сайн болох түүнийг үйлдэв; мөн тэрээр олон хөвгүүд болоод охидыг төрүүлжээ; мөн тэрээр олон өдрийг үзсэний дараа, дэлхийн бусадтай адилаар тэрээр нас нөгчив; мөн Киш түүний оронд засаглав.

18 Мөнхүү улиран тохиох дор Киш түүнчлэн нас нөгчиж, мөн Либ түүний оронд засаглав.

19 Мөнхүү улиран тохиох дор Либ түүнчлэн Их Эзэний мэлмийд сайн болох түүнийг үйлдэв. Мөн Либийн өдрүүдэд хорт могойнууд устгагдав. Иймийн тул тэд өмнө зүгийн нутаг тийш, уг нутгийн хүмүүст хүнс болгохоор ан хийхийн тулд явцгаав, учир нь уг нутаг ойн амьтдаар бүрхэгдсэн байв. Мөн Либ түүнчлэн өөрөө агуу анчин болов.

20 Мөн тэд нутгийн нарийн хоолойвчид, нутгийг тэнгис хувааж буй хэсэг газрын дэргэд нэгэн агуу хот байгуулав.

21 Мөн тэд өмнө зүгийн нутгийг, ан авын тулд, аглаг буйд хэвээр нь хадгалав. Мөн хойд зүгийн бүх нутгийн гадаргуу оршин суугчдаар дүүрэв.

22 Мөн тэд үлэмж хөдөлмөрч байв, мөн тэд худалдан авч мөн худалдаж мөн тэд олж болохын тулд, нэг нэгэнтэйгээ арилжаа хийж байв.

And his brother did rise up in rebellion against him, by which he did bring him into captivity; and he did remain in captivity all his days; and he begat sons and daughters in captivity, and in his old age he begat Levi; and he died.

And it came to pass that Levi did serve in captivity after the death of his father, for the space of forty and two years. And he did make war against the king of the land, by which he did obtain unto himself the kingdom.

And after he had obtained unto himself the kingdom he did that which was right in the sight of the Lord; and the people did prosper in the land; and he did live to a good old age, and begat sons and daughters; and he also begat Corom, whom he anointed king in his stead.

And it came to pass that Corom did that which was good in the sight of the Lord all his days; and he begat many sons and daughters; and after he had seen many days he did pass away, even like unto the rest of the earth; and Kish reigned in his stead.

And it came to pass that Kish passed away also, and Lib reigned in his stead.

And it came to pass that Lib also did that which was good in the sight of the Lord. And in the days of Lib the poisonous serpents were destroyed. Wherefore they did go into the land southward, to hunt food for the people of the land, for the land was covered with animals of the forest. And Lib also himself became a great hunter.

And they built a great city by the narrow neck of land, by the place where the sea divides the land.

And they did preserve the land southward for a wilderness, to get game. And the whole face of the land northward was covered with inhabitants.

And they were exceedingly industrious, and they did buy and sell and traffic one with another, that they might get gain.

23 Мөн тэд бүх л төрлийн хүдэртэй ажиллаж, мөн тэд алт, мөн мөнгө, мөн төмөр, мөн гууль, мөн бүх л төрлийн төмөрлөгүүдийг гаргаж байв; мөн тэд түүнийг газраас олборлож байв; иймийн тул, тэд алтны, мөн мөнгөний, мөн төмрийн, мөн зэсийн хүдэр гаргаж авахын тулд ихээхэн газрын хөрсийг овоолсон байлаа. Мөн тэд бүх төрлийн сайн бүтээлүүдийг үйлдэв.

24 Мөн тэд торго, мөн нарийн нэхээст бөс даавуутай байв; мөн тэд өөрсдийн нүцгэнийг халхлахаар, бүх төрлийн бөс даавуу хийж байв.

25 Мөн тэд газар боловсруулах, хагалах мөн тарих, хадах мөн зээтүүдэх, мөн түүнчлэн цайруулах бүх төрлийн багажнууд хийв.

26 Мөн тэд амьтдаа ажиллуулах бүх төрлийн багажууд хийв.

27 Мөн тэд дайны бүх төрлийн зэвсгүүд хийв. Мөн тэд бүх л төрлийн үлэмж уран чамин хийцтэй бүтээлүүд үйлдэв.

28 Мөн Их Эзэний мутраар тэднээс илүү адислагдсан, мөн илүү хөгжүүлэгдсэн хүмүүс хэзээ ч байх аргагүй юм. Мөн тэд бүх нутгаас дээгүүр сонгомол нутагт байлаа, учир нь Их Эзэн үүнийг хэлсэн бөлгөө.

29 Мөнхүү улиран тохиох дор Либ олон жил амьдарч, мөн хөвгүүд болоод охидыг; мөн тэрээр түүнчлэн Харфомыг төрүүлэв.

30 Мөнхүү улиран тохиох дор Харфом эцгийнхээ оронд засаглав. Мөн Харфом хорин дөрвөн жил засагласан үед, болгоогтун, хаант улс түүнээс булаагдан авагдав. Мөн тэрээр олон жилийг, тийм ээ, бүр өөрийн өдрүүдийн бүх үлдсэнийг боолчлолд үйлчлэв.

31 Мөн тэрээр Хетийг төрүүлж, мөн Хет өөрийн бүх өдрүүдэд боолчлолд амьдарсан буюу. Мөн Хет Аароныг төрүүлж, мөн Аарон өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Амнигаддаг төрүүлж, мөн Амнигадда түүнчлэн өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Кориантумыг төрүүлж, мөн Кориантум өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Комыг төрүүлэв.

And they did work in all manner of ore, and they did make gold, and silver, and iron, and brass, and all manner of metals; and they did dig it out of the earth; wherefore, they did cast up mighty heaps of earth to get ore, of gold, and of silver, and of iron, and of copper. And they did work all manner of fine work.

And they did have silks, and fine-twined linen; and they did work all manner of cloth, that they might clothe themselves from their nakedness.

And they did make all manner of tools to till the earth, both to plow and to sow, to reap and to hoe, and also to thrash.

And they did make all manner of tools with which they did work their beasts.

And they did make all manner of weapons of war. And they did work all manner of work of exceedingly curious workmanship.

And never could be a people more blessed than were they, and more prospered by the hand of the Lord. And they were in a land that was choice above all lands, for the Lord had spoken it.

And it came to pass that Lib did live many years, and begat sons and daughters; and he also begat Hearthom.

And it came to pass that Hearthom reigned in the stead of his father. And when Hearthom had reigned twenty and four years, behold, the kingdom was taken away from him. And he served many years in captivity, yea, even all the remainder of his days.

And he begat Heth, and Heth lived in captivity all his days. And Heth begat Aaron, and Aaron dwelt in captivity all his days; and he begat Amnigaddah, and Amnigaddah also dwelt in captivity all his days; and he begat Coriantum, and Coriantum dwelt in captivity all his days; and he begat Com.

- 32 Мөнхүү улиран тохиох дор Ком хаант улсын хагасыг дагуулан одов. Мөн тэрээр хаант улсын хагасын дээр дөчин хоёр жил засаглав; мөн тэрээр хаан Амгидын эсрэг тулалдаанд орж, мөн тэд олон жилийн туршид тулалдан, энэ цагийн хооронд Ком Амгидын дээр хүчийг олж, мөн хаант улсын үлдсэн хэсгийн дээр хүчийг олж авсан бөлгөө.
- 33 Мөн Комын өдрүүдэд уг нутагт дээрэмчид байж эхлэв; мөн тэд хуучин төлөвлөгөөнүүдийг авч хэрэглэн, мөн эртнийхний адилаар тангараг үйлдэх болов, мөн хаант улсыг устгахаар дахин эрэлхийлэв.
- 34 Эдүгээ Ком тэдний эсрэг маш их тулалдаж байв; гэсэн хэдий ч, тэр тэднийг дийлсэн нь үгүй.

And it came to pass that Com drew away the half of the kingdom. And he reigned over the half of the kingdom forty and two years; and he went to battle against the king, Amgid, and they fought for the space of many years, during which time Com gained power over Amgid, and obtained power over the remainder of the kingdom.

And in the days of Com there began to be robbers in the land; and they adopted the old plans, and administered oaths after the manner of the ancients, and sought again to destroy the kingdom.

Now Com did fight against them much; nevertheless, he did not prevail against them.

## Ифер 11

- 1 Мөн түүнчлэн Комын өдрүүдэд олон бошиглогч ирж, мөн тэр агуу хүмүүс наманчилж, мөн Их Эзэнд хандан, мөн өөрсдийн аллага хийгээд ёс бусын үйлээ орхих ёстойг, эс бөгөөс тэдний устгалын тухай бошиглов.
- 2 Мөнхүү улиран тохиох дор бошиглогчид хүмүүсээр эсэргүүцэгдэв, мөн хүмүүс тэднийг устгахаар эрэлхийлсний учир, тэд хамгаалахыг хүсэн Комд зугтаж очив.
- 3 Мөн тэд Комд олон зүйлийг бошиглов; мөн тэрээр өөрийн өдрүүдийн үлдсэн хугацаанд адислагдав.
- 4 Мөн тэрээр их өндөр насыг хүртэл амьдарч, мөн Шибломыг төрүүлэв; мөн Шиблом түүний оронд засаглав. Мөн Шибломын дүү түүний эсрэг босож, мөн бүх л нутагт үлэмж агуу дайн эхлэв.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Шибломын дүү хүмүүсийн устгалын талаар бошиглосон бүх бошиглогчдыг үхэлд хүргэгдэх болгов;
- 6 Мөн бүх нутагт агуу гай гамшиг тохиов, учир нь тэд өөрсдийн ёс бус үйлээсээ наманчлахгүй аваас агуу зүхэл уг нутагт, мөн түүнчлэн хүмүүсийн дээр ирэх болно, мөн тэдний дунд, газрын гадаргуу дээр хэзээ ч байгаагүй тийм агуу устгал байх болно, мөн тэдний яс нутгийн гадаргуу дээр газрын овоологдсон хөрс лугаа адил болно хэмээн тэд гэрчилж байв.
- 7 Мөн тэд өөрсдийн ёс бус хуйвалдаануудын улмаас Их Эзэний дуу хоолойг сонссон нь үгүй; иймийн тул, бүх нутагт дайн мөн зөрчилдөөн байв, мөн түүнчлэн олон өлсгөлөн мөн тахал байж эхлэв, үүний хэрээр, газрын гадаргуу дээр хэзээ ч байгаагүй тийм агуу устгал болов; мөнхүү энэ бүхэн Шибломын өдрүүдэд улиран тохиосон ажгуу.
- 8 Мөн хүмүүс алдсаа наманчилж эхлэв; мөн тэгсний хэрээр Их Эзэн тэдэнд нигүүлсэл үзүүлэв.
- 9 Мөнхүү улиран тохиох дор Шиблом хөнөөгдөв, мөн Сет боолчлолд авчрагдаж, мөн өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршсон буюу.

## Ether 11

And there came also in the days of Com many prophets, and prophesied of the destruction of that great people except they should repent, and turn unto the Lord, and forsake their murders and wickedness.

And it came to pass that the prophets were rejected by the people, and they fled unto Com for protection, for the people sought to destroy them.

And they prophesied unto Com many things; and he was blessed in all the remainder of his days.

And he lived to a good old age, and begat Shiblom; and Shiblom reigned in his stead. And the brother of Shiblom rebelled against him, and there began to be an exceedingly great war in all the land.

And it came to pass that the brother of Shiblom caused that all the prophets who prophesied of the destruction of the people should be put to death;

And there was great calamity in all the land, for they had testified that a great curse should come upon the land, and also upon the people, and that there should be a great destruction among them, such an one as never had been upon the face of the earth, and their bones should become as heaps of earth upon the face of the land except they should repent of their wickedness.

And they hearkened not unto the voice of the Lord, because of their wicked combinations; wherefore, there began to be wars and contentions in all the land, and also many famines and pestilences, insomuch that there was a great destruction, such an one as never had been known upon the face of the earth; and all this came to pass in the days of Shiblom.

And the people began to repent of their iniquity; and inasmuch as they did the Lord did have mercy on them.

And it came to pass that Shiblom was slain, and Seth was brought into captivity, and did dwell in captivity all his days.

10 Мөнхүү улиран тохиох дор түүний хүү Аха хаант улсыг авав; мөн тэрээр өөрийн бүх өдрүүдэд хүмүүсийн дээр засагласан бөлгөө. Мөн тэрээр өөрийн өдрүүдэд бүх төрлийн алдсыг хийсэн болой, тэгснээр тэр маш их цус урсах болгов; мөн цөөхөн байсан болой түүний өдрүүд.

11 Мөн Ифем, Ахагийн удам байсан тул, хаант улсыг авав; мөн тэрээр өөрийн өдрүүдэд түүнчлэн ёс бус болох түүнийг үйлдсэн бөлгөө.

12 Мөнхүү улиран тохиох дор Ифемийн өдрүүдэд олон бошиглогчид ирж, мөн хүмүүст дахин бошиглов; тийм ээ, тэд алдсуудаа наманчлахгүй аваас Их Эзэн тэднийг газрын гадаргуу дээрээс бүрмөсөн устгах болно хэмээн тэд бошиглосон ажээ.

13 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж, мөн тэдний үгийг анхааран сонсохгүй байв; мөн бошиглогчид гашуудаж мөн хүмүүсийн дундаас холдон явав.

14 Мөнхүү улиран тохиох дор Ифем өөрийн бүх өдрүүдэд хууль цаазыг ёс бусаар хэрэгжүүлж байв; мөн тэрээр Мороныг төрүүлэв. Мөнхүү улиран тохиох дор Морон түүний оронд засаглав; мөн Морон Их Эзэний өмнө ёс бус болох түүнийг үйлдсэн буюу.

15 Мөнхүү улиран тохиох дор хүмүүсийн дунд, хүч хийгээд эд хөрөнгийг олохоор бий болсон нууц хуйвалдааны улмаас бослого гарав; мөн тэдний дунд алдастаа хүчирхэг нэгэн эр босож мөн Моронтой тулаанд оров, тэгснээр тэрбээр хаант улсын хагасыг унагав; мөн тэрээр хаант улсын хагасыг олон жилд барьсан болой.

16 Мөнхүү улиран тохиох дор Морон түүнийг унагаж, мөн хаант улсыг дахин авав.

17 Мөнхүү улиран тохиох дор бас нэгэн хүчит эр гарч ирэв; мөн тэрбээр Жаредын ахын удам байв.

18 Мөнхүү улиран тохиох дор тэрээр Мороныг унагаж мөн хаант улсыг авав; иймийн тул, Морон өөрийн үлдсэн бүх өдрүүдэд боолчлолд оршив; мөн тэрээр Корианторыг төрүүлэв.

19 Мөнхүү улиран тохиох дор Кориантор өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршсон авай.

And it came to pass that Ahah, his son, did obtain the kingdom; and he did reign over the people all his days. And he did do all manner of iniquity in his days, by which he did cause the shedding of much blood; and few were his days.

And Ethem, being a descendant of Ahah, did obtain the kingdom; and he also did do that which was wicked in his days.

And it came to pass that in the days of Ethem there came many prophets, and prophesied again unto the people; yea, they did prophesy that the Lord would utterly destroy them from off the face of the earth except they repented of their iniquities.

And it came to pass that the people hardened their hearts, and would not hearken unto their words; and the prophets mourned and withdrew from among the people.

And it came to pass that Ethem did execute judgment in wickedness all his days; and he begat Moron. And it came to pass that Moron did reign in his stead; and Moron did that which was wicked before the Lord.

And it came to pass that there arose a rebellion among the people, because of that secret combination which was built up to get power and gain; and there arose a mighty man among them in iniquity, and gave battle unto Moron, in which he did overthrow the half of the kingdom; and he did maintain the half of the kingdom for many years.

And it came to pass that Moron did overthrow him, and did obtain the kingdom again.

And it came to pass that there arose another mighty man; and he was a descendant of the brother of Jared.

And it came to pass that he did overthrow Moron and obtain the kingdom; wherefore, Moron dwelt in captivity all the remainder of his days; and he begat Coriantor.

And it came to pass that Coriantor dwelt in captivity all his days.



20 Мөн Корианторын өдрүүдэд түүнчлэн олон бошиглогчид иржээ, мөн агуу хийгээд гайхамшигт зүйлийг бошиглож, мөн тэд наманчлахгүй аваас Их Эзэн Бурхан тэднийг бүрмөсөн устгалд хүргэх хууль цаазыг тэдний эсрэг хэрэгжүүлэх болно хэмээн хүмүүст наманчлалыг тунхаглав;

21 Мөн Их Эзэн Бурхан өөрийн хүчээр, уг нутгийг эзэмшүүлэхээр, тэрээр тэдний эцэг дээдсийг авчирсан тэр байдлаар, бусад хүмүүсийг илгээх болно, өөрөөр хэлбэл авчрах болно гэв.

22 Мөн өөрсдийн нууц нийгэмлэг хийгээд ёс бус жигшүүрт үйлүүдийн улмаас тэд бошиглогчдын бүх үгсийг эсэргүүцсэн болой.

23 Мөнхүү улиран тохиох дор Кориантор Иферийг төрүүлэв, мөн тэрээр, өөрийн бүх өдрүүдэд боолчлолд оршоор нас нөгчив.

And in the days of Coriantor there also came many prophets, and prophesied of great and marvelous things, and cried repentance unto the people, and except they should repent the Lord God would execute judgment against them to their utter destruction;

And that the Lord God would send or bring forth another people to possess the land, by his power, after the manner by which he brought their fathers.

And they did reject all the words of the prophets, because of their secret society and wicked abominations.

And it came to pass that Coriantor begat Ether, and he died, having dwelt in captivity all his days.

## Ифер 12

- 1 Мөнхүү улиран тохиох дор Иферийн өдрүүд Кориантумрын өдрүүдэд байв; мөн Кориантумр бүх нутгийн дээр хаан байлаа.
- 2 Мөн Ифер Их Эзэний бошиглогч байв; иймийн тул Ифер Кориантумрын өдрүүдэд ирж, мөн хүмүүст бошиглож эхлэв, учир нь түүнд орших Их Эзэний Сүнсний улмаас тэрээр зогсоогдож чадаагүй байв.
- 3 Тэрээр өглөөнөөс эхлэн бүр нар жаргах хүртэл, хүмүүсийг наманчлалд хүргэх Бурханд итгэхийг, эс бөгөөс тэд устгагдах болуузай хэмээн ухуулан, итгэлээр бүх зүйлс гүйцэлддэгийг тэдэнд хэлэн тунхаглав—
- 4 Иймийн тул, Бурханд итгэдэг хэн боловч, илүү сайн дэлхийд, тийм ээ, Бурханы баруун гар талд байх нэгэн байрны төлөө лавтайяа найдаж болох, уг найдвар нь итгэлээр ирж, хүмүүсийн бодгальд зангуу болдог, тэр нь тэднийг тууштай мөн хөдөлшгүй сайн үйлээр үргэлж дүүрэн, бас Бурханыг алдаршуулахад удирдагдах болгодог.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Ифер агуу хийгээд гайхамшигт зүйлийг хүмүүст бошиглосон аж, тэд тэдгээрийг эс үзсэний учир, тэд тэдгээрт нь итгэсэнгүй.
- 6 Мөн эдүгээ, би, Моронай, эдгээр зүйлийн талаар заримыг ярьж; итгэл бол найдагдсан боловч үзэгдээгүй зүйлүүд гэдгийг би дэлхийд үзүүлнэ; иймийн тул, та нар хараагүйн улмаас бүү арсалд, учир нь итгэлийн тань сорилтын дарааг хүртэл та нар гэрчийг хүлээн авахгүй.
- 7 Учир нь Христ бидний өвөг дээдэст, тэрээр үхлээс боссоныхоо дараа, өөрийгөө үзүүлсэн нь итгэлээр байсан буюу; мөн тэднийг өөрт нь итгэлтэй болсны дарааг хүртэл тэрээр өөрийгөө тэдэнд үзүүлээгүй юм; иймийн тул, түүнд зарим нь итгэлтэй байсан гэдэг нь зайлшгүй, учир нь тэрээр өөрийгөө дэлхийд үзүүлээгүй.
- 8 Гэвч хүмүүсийн итгэлийн улмаас тэрээр өөрийгөө дэлхийд үзүүлж, мөн Эцэгийн нэрийг алдаршуулан, мөн бусад зарим нь тэнгэрлэг бэлгээс хүртэгсэд байж болохын тулд, тэд үзээгүй зүйлүүддээ найдаж болохын тулд замыг бэлтгэсэн бөлгөө.

## Ether 12

And it came to pass that the days of Ether were in the days of Coriantumr; and Coriantumr was king over all the land.

And Ether was a prophet of the Lord; wherefore Ether came forth in the days of Coriantumr, and began to prophesy unto the people, for he could not be restrained because of the Spirit of the Lord which was in him.

For he did cry from the morning, even until the going down of the sun, exhorting the people to believe in God unto repentance lest they should be destroyed, saying unto them that by faith all things are fulfilled—

Wherefore, whoso believeth in God might with surety hope for a better world, yea, even a place at the right hand of God, which hope cometh of faith, maketh an anchor to the souls of men, which would make them sure and steadfast, always abounding in good works, being led to glorify God.

And it came to pass that Ether did prophesy great and marvelous things unto the people, which they did not believe, because they saw them not.

And now, I, Moroni, would speak somewhat concerning these things; I would show unto the world that faith is things which are hoped for and not seen; wherefore, dispute not because ye see not, for ye receive no witness until after the trial of your faith.

For it was by faith that Christ showed himself unto our fathers, after he had risen from the dead; and he showed not himself unto them until after they had faith in him; wherefore, it must needs be that some had faith in him, for he showed himself not unto the world.

But because of the faith of men he has shown himself unto the world, and glorified the name of the Father, and prepared a way that thereby others might be partakers of the heavenly gift, that they might hope for those things which they have not seen.

9 Иймийн тул, та нар ч түүнчлэн, хэрэв та нар итгэлтэй л байх аваас, найдварыг агуулж, мөн уг бэлгээс хүртэгсэд байж болно.

10 Болгоогтун эртний тэд Бурханы ариун жаягаар дуудагдсан нь итгэлээр байсан буюу.

11 Иймийн тул, Мосегийн хууль өгөгдсөн нь итгэлээр байсан юм. Гэвч өөрийн Хүүгийн бэлгээр Бурхан илүүтэй онцгой замыг бэлтгэсэн бөлгөө; мөн үүний гүйцэлдсэн нь итгэлээр юм.

12 Учир нь хэрэв хүмүүний үрсийн дунд итгэл үгүй бол Бурхан тэдний дунд ямар ч гайхамшгийг үйлдэж эс чадах буюу; иймийн тул, тэдний итгэлийн дарааг хүртэл тэрээр өөрийгөө үзүүлээгүй.

13 Болгоогтун, шоронг газарт нуран унах болгосон нь Алма Амюлек хоёрын итгэл байсан юм.

14 Болгоогтун, тэд галаар мөн Ариун Сүнсээр баптисм хүртэхэд хүргэх өөрчлөлтийг леменчүүдийн дээр авчирсан нь Нифай Лихай хоёрын итгэл байсан юм.

15 Болгоогтун, леменчүүдийн дунд нэтэд агуу гайхамшгийг үйлдсэн нь Аммон мөн түүний ахан дүүсийн итгэл байсан юм.

16 Тийм ээ, мөн гайхамшгийг үйлдсэн бүр тэд бүгд нь, бүр Христийн өмнө мөн басхүү дараа нь байсан тэд, тэдгээрийг итгэлээр үйлдсэн юм.

17 Мөн уг гурван шавь үхлийг эс амсана хэмээх амлалтыг олж авсан нь итгэлээр байсан юм; мөн тэд итгэлийнхээ дарааг хүртэл амлалтыг олж авсан нь үгүй.

18 Мөн итгэлийнхээ дарааг хүртэл хэн ч хэзээ ч гайхамшгийг үйлдсэн нь үгүй; иймийн тул тэд эхлээд Бурханы Хүүд итгэсэн бөлгөө.

19 Мөн гивлүүрийн гадна хадгалагдаж чадахааргүй тэд, харин итгэлийн нүдээр болгоосон тэр зүйлийг өөрсдийн нүдээр үнэхээр хараад мөн баяртай байлаа, итгэл нь тийм үлэмж хүчирхэг байсан тэд бүр Христийг ирэхээс өмнө ч олон байв.

20 Мөн болгоогтун, эдгээрийн нэг нь Жаредын ах байсныг бид энэхүү цэдэгт үзсэн бөлгөө; учир нь түүний итгэлээрээ олж авсан үг болох, Бурхан өөрөө түүнд хэлсэн үгийн учир, тэр хуруугаа сунгахад, Жаредын ахын харцнаас нууж эс чадахаар Бурханд итгэх түүний итгэл тийм агуу байв.

Wherefore, ye may also have hope, and be partakers of the gift, if ye will but have faith.

Behold it was by faith that they of old were called after the holy order of God.

Wherefore, by faith was the law of Moses given. But in the gift of his Son hath God prepared a more excellent way; and it is by faith that it hath been fulfilled.

For if there be no faith among the children of men God can do no miracle among them; wherefore, he showed not himself until after their faith.

Behold, it was the faith of Alma and Amulek that caused the prison to tumble to the earth.

Behold, it was the faith of Nephi and Lehi that wrought the change upon the Lamanites, that they were baptized with fire and with the Holy Ghost.

Behold, it was the faith of Ammon and his brethren which wrought so great a miracle among the Lamanites.

Yea, and even all they who wrought miracles wrought them by faith, even those who were before Christ and also those who were after.

And it was by faith that the three disciples obtained a promise that they should not taste of death; and they obtained not the promise until after their faith.

And neither at any time hath any wrought miracles until after their faith; wherefore they first believed in the Son of God.

And there were many whose faith was so exceedingly strong, even before Christ came, who could not be kept from within the veil, but truly saw with their eyes the things which they had beheld with an eye of faith, and they were glad.

And behold, we have seen in this record that one of these was the brother of Jared; for so great was his faith in God, that when God put forth his finger he could not hide it from the sight of the brother of Jared, because of his word which he had spoken unto him, which word he had obtained by faith.

21 Мөн Жаредын ахын итгэлээр олж авсан амлалтын улмаас, Жаредын ах Их Эзэний хурууг болгоосны дараа, Их Эзэн түүний харцнаас юуг ч зайлуулж эс чадсан бөлгөө; иймийн тул тэрээр түүнд бүх зүйлийг үзүүлсэн аж, учир нь тэрээр гивлүүрийн гадна цаашид хадгалагдаж эс чадсан буюу.

22 Мөн миний эцэг дээдэс эдгээр зүйлийг тэдний ахан дүүст харийнханаар дамжуулан ирүүлнэ гэсэн амлалт олж авсан нь итгэлээр байсан юм; тиймийн тул Их Эзэн, тийм ээ, бүр Есүс Христ надад зарлигласан бөлгөө.

23 Мөн би түүнд хэлэв: Их Эзэн, бидний бичгийн сул дорой байдлын улмаас, харийнхан эдгээр зүйлийг шоолох болно; учир нь Их Эзэн та биднийг ярихдаа хүчтэй болгосон, гэвч та биднийг бичихдээ хүчит болгосон нь үгүй; учир нь та өөрийн тэдэнд өгсөн Ариун Сүнсний улмаас, энэ бүх хүмүүсийг, тэд ихийг ярьж чадахаар болгосон билээ;

24 Мөн бидний гар болхийн улмаас, та биднийг багыг л бичиж чаддаг болгосон буюу. Болгоогтун, та биднийг Жаредын ахын адил бичихдээ хүчтэй болгосон нь үгүй, учир нь түүний бичсэн зүйлүүд, тэдгээрийг унших болгон хүмүүнийг эзэмдэхүйц таны адил тийм хүчтэй байхаар түүнийг хүчирхэг болгосон бөлгөө.

25 Бид бүр бичиж чадахааргүйгээр, та бидний үгсийг хүчирхэг мөн агуу болгосон; иймийн тул, бичихдээ бид өөрсдийн сул доройг болгоож, мөн өөрсдийн үгийг байрлуулахын улмаас бүдэчдэг; мөн харийнхан бидний үгсийг шоолох буйза хэмээн би эмээнэ.

26 Мөн би үүнийг хэлэхэд, Их Эзэн надад ярьж, хэлрүүн: Тэнэгүүд шоолдог, гэвч тэд гашуудах болно; мөн тэд та нарын сул доройг үл ашиглахын тулд, номхон дөлгөөн тэдэнд миний ач ивээл хангалттай;

27 Мөн хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд өөрсдийнх нь сул доройг үзүүлэх болно. Тэд даруу байж болохын тулд би хүмүүст сул доройг өгдөг; мөн миний өмнө өөрсдийгөө даруусгадаг бүх хүмүүст миний ач ивээл хангалттай; учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгаж, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө.

And after the brother of Jared had beheld the finger of the Lord, because of the promise which the brother of Jared had obtained by faith, the Lord could not withhold anything from his sight; wherefore he showed him all things, for he could no longer be kept without the veil.

And it is by faith that my fathers have obtained the promise that these things should come unto their brethren through the Gentiles; therefore the Lord hath commanded me, yea, even Jesus Christ.

And I said unto him: Lord, the Gentiles will mock at these things, because of our weakness in writing; for Lord thou hast made us mighty in word by faith, but thou hast not made us mighty in writing; for thou hast made all this people that they could speak much, because of the Holy Ghost which thou hast given them;

And thou hast made us that we could write but little, because of the awkwardness of our hands. Behold, thou hast not made us mighty in writing like unto the brother of Jared, for thou madest him that the things which he wrote were mighty even as thou art, unto the overpowering of man to read them.

Thou hast also made our words powerful and great, even that we cannot write them; wherefore, when we write we behold our weakness, and stumble because of the placing of our words; and I fear lest the Gentiles shall mock at our words.

And when I had said this, the Lord spake unto me, saying: Fools mock, but they shall mourn; and my grace is sufficient for the meek, that they shall take no advantage of your weakness;

And if men come unto me I will show unto them their weakness. I give unto men weakness that they may be humble; and my grace is sufficient for all men that humble themselves before me; for if they humble themselves before me, and have faith in me, then will I make weak things become strong unto them.

28 Болгоогтун, харийнханд би сул доройг нь үзүүлэх болно, мөн итгэл, найдвар хийгээд энэрэл нь надад авчирдгийг—бүх зөв шударгын эх булагт би тэдэнд үзүүлэх болно.

29 Мөн би, Моронай, эдгээр үгсийг сонсоод, тайтга-руулагдаж, мөн хэлэв: Ай Их Эзэн, таны зөв шударга таалал гүйцэлдэх болтугай, учир нь та хүмүүний үрсэд тэдний итгэлийн дагуу үйлддэг билээ;

30 Учир нь Жаредын ах Зерин ууланд, нүү хэмээн хэлэхэд—тэр нь нүүлгэгдсэн шүү дээ. Мөн хэрэв тэрээр итгэлгүй байсан бол тэр нь нүүхгүй байсан; иймийн тул хүмүүс итгэлийг агуулсны дараа л та үйлддэг шүү дээ.

31 Учир нь тийн та өөрийгөө шавь нартаа үзүүлсэн; учир нь тэд итгэлийг агуулсны, мөн таны нэрээр ярьсны дараа, та өөрийгөө тэдэнд агуу хүчтэйгээр үзүүлсэн буюу.

32 Мөн түүнчлэн түүнд хүмүүн илүү онцгой найдвар тавьж болох өргөөг та хүмүүнд, тийм ээ, таны Эцэгийн эзэмшлүүдийн дунд бэлтгэсэн хэмээн таны хэлснийг би санаж байна; иймийн тул хүмүүн найдах ёстой, эс бөгөөс тэрээр таны бэлтгэсэн тэр байранд өв хүртэж чадахгүй.

33 Мөн түүнчлэн, та дэлхийнхэнд хайртай, бүр өөрийн амийг дэлхийнхний төлөө өгөх хүртлээ, хүмүүний үрсэд нэгэн байрыг бэлтгэхийн тулд үүнийг эргүүлж авна хэмээн хэлснийг тань би санаж байна.

34 Мөн эдүгээ хүмүүний үрсэд зориулсан таны хайр бол энэрэл гэдгийг би мэднэ; иймийн тул, хүмүүс энэрэлтэй байхаас бусдаар, Эцэгийнхээ эзэмшлүүдэд таны бэлтгэсэн тэрхүү байрыг өвлөж чадахгүй.

35 Иймийн тул, бидний сул доройн улмаас, хэрэв харийнхан энэрэл үгүй аваас, та тэднийг сорьж, мөн тэдний талантыг нь авч, тийм ээ, бүр тэдний хүлээн авсан түүнийг нь, мөн илүү элбэг хангалуун буй тэдэнд өгөх болно хэмээн таны хэлсэн энэ зүйлээр би мэднэ.

36 Мөнхүү улиран тохиох дор тэд энэрлийг агуулж болохын тулд, тэрээр харийнханд ач ивээлийг хайрлаасай хэмээн Их Эзэнд хандан залбирсан буюу би.

Behold, I will show unto the Gentiles their weakness, and I will show unto them that faith, hope and charity bringeth unto me—the fountain of all righteousness.

And I, Moroni, having heard these words, was comforted, and said: O Lord, thy righteous will be done, for I know that thou workest unto the children of men according to their faith;

For the brother of Jared said unto the mountain Zerin, Remove—and it was removed. And if he had not had faith it would not have moved; wherefore thou workest after men have faith.

For thus didst thou manifest thyself unto thy disciples; for after they had faith, and did speak in thy name, thou didst show thyself unto them in great power.

And I also remember that thou hast said that thou hast prepared a house for man, yea, even among the mansions of thy Father, in which man might have a more excellent hope; wherefore man must hope, or he cannot receive an inheritance in the place which thou hast prepared.

And again, I remember that thou hast said that thou hast loved the world, even unto the laying down of thy life for the world, that thou mightest take it again to prepare a place for the children of men.

And now I know that this love which thou hast had for the children of men is charity; wherefore, except men shall have charity they cannot inherit that place which thou hast prepared in the mansions of thy Father.

Wherefore, I know by this thing which thou hast said, that if the Gentiles have not charity, because of our weakness, that thou wilt prove them, and take away their talent, yea, even that which they have received, and give unto them who shall have more abundantly.

And it came to pass that I prayed unto the Lord that he would give unto the Gentiles grace, that they might have charity.

- 37 Мөнхүү улиран тохиох дор Их Эзэн надад хэл-  
рүүн: Хэрэв тэд энэрэл үгүй аваас, энэ нь чамд хамаа-  
гүй болой; чи итгэлтэй байсан; иймийн тул, чиний  
өмсгөл цэвэр болгогдох болно. Мөн чи өөрийн сул  
доройг харсны учир чи, миний Эцэгийн эзэмшилд  
миний бэлтгэсэн байранд суух хүртэл хүчирхэг бол-  
гогдох болно.
- 38 Мөн эдүгээ, би, Моронай, харийнханд, тийм ээ,  
мөн түүнчлэн өөрийн хайрладаг ах дүүстээ, миний  
өмсгөлүүдэд та нарын цусны толбо үгүйг бүх хүмүүс  
мэдэх Христийн шүүлтийн суудлын өмнө бид уул-  
зах хүртэл сайныг ерөөе.
- 39 Мөн би Есүсийг харсан, мөн нэг хүмүүн нөгөөдөө  
хэлэхийн адилаар, тэрээр надтай нүүр тулан ярьсан,  
мөн тэрээр энгийн даруу байдлаар, миний хэлээр эд-  
гээр зүйлүүдийн талаар хэлснийг тийн та нар мэдэх  
болно;
- 40 Мөн миний бичих нь сул доройн улмаас, би зөв-  
хөн цөөн хэдийг бичсэн бөлгөө.
- 41 Мөн эдүгээ, Бурхан Эцэгийн мөн түүнчлэн Их  
Эзэн Есүс Христийн, мөн тэднийг гэрчилдэг Ариун  
Сүнсний ач ивээл та нарт оршин байж мөн үүрд үл-  
дэхийн тулд бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн  
тухайлан бичсэн Есүсийг эрэлхийлэхийг би та нарт  
уриалж байна. Амен.

And it came to pass that the Lord said unto me: If  
they have not charity it mattereth not unto thee, thou  
hast been faithful; wherefore, thy garments shall be  
made clean. And because thou hast seen thy weakness  
thou shalt be made strong, even unto the sitting down  
in the place which I have prepared in the mansions of  
my Father.

And now I, Moroni, bid farewell unto the Gentiles,  
yea, and also unto my brethren whom I love, until we  
shall meet before the judgment-seat of Christ, where all  
men shall know that my garments are not spotted with  
your blood.

And then shall ye know that I have seen Jesus, and  
that he hath talked with me face to face, and that he told  
me in plain humility, even as a man telleth another in  
mine own language, concerning these things;

And only a few have I written, because of my weak-  
ness in writing.

And now, I would commend you to seek this Jesus of  
whom the prophets and apostles have written, that the  
grace of God the Father, and also the Lord Jesus Christ,  
and the Holy Ghost, which beareth record of them,  
may be and abide in you forever. Amen.

## Ифер 13

- 1 Мөн эдүгээ, би, Моронай, өөрийн бичиж асан хүмүүсийн устгалын талаарх өөрийн цэдгийг дуусгахаа үргэлжлүүлэе.
- 2 Учир нь болгоогтун, тэд Иферийн бүх үгсийг эсэргүүцсэн бөлгөө; учир нь хүмүүний эхлэлээс эхлэн бүх зүйлийн тухай; мөн энэ нутгийн гадаргуугаас ус ширгэсний дараа энэ нь бусад бүх нутгийн дээгүүр сонгомол нутаг, Их Эзэний сонгосон нутаг болсныг; иймийн тул Их Эзэн үүний гадаргуу дээр оршин суусан бүх хүмүүс өөрт нь үйлчлээсэй хэмээснийг тэрээр үнэнээр хэлсэн буюу;
- 3 Мөн энэ нь тэнгэрээс бууж ирэхийг, Шинэ Иерусалимын, мөн Их Эзэний ариун дуганы газар болохыг.
- 4 Болгоогтун, Ифер Христийн өдрүүдийг харж, мөн тэрээр энэ нутаг дээрх Шинэ Иерусалимын талаар ярьсан буюу.
- 5 Мөн тэрбээр түүнчлэн Израилын угсааны, мөн Лихайн тэндээс ирэх тэр Иерусалимын талаар ярьж байв—энэ нь устгагдсаны дараа, Их Эзэний тулд ариун хот болон дахин баригдах болно; иймийн тул, энэ нь хуучны цагт байсан учир шинэ Иерусалим байх аргагүй юм; гэвч энэ нь дахин баригдана, мөн Их Эзэний тулд ариун хот болно; мөн энэ нь Израилын угсааны төлөө баригдах болно—
- 6 Мөн Шинэ Иерусалим энэ нутагт, Иосефын үр удмын үлдэгдлийн тулд баригдах болно, учир нь тэдгээр зүйлүүдийн хэв шинж юм.
- 7 Учир нь, Иосеф өөрийн эцгийг доош Египетийн нутагт авчирсанчлан, тэрээр тийн тэнд нас нөгчсөн; иймийн тул, тэр эрсдэхгүйн тулд Иосефын эцэгт тэрээр нигүүлсэнгүй байсныхаа адилаар, Иосефын үрсэд, тэд эрсдэхгүйн тулд тэрээр тэдэнд нигүүлсэнгүй байх учир Их Эзэн Иосефын үр удмын нэгэн үлдэгдлийг Иерусалимын нутгаас гарган авчирсан буюу.
- 8 Иймийн тул, Иосефын угсааны үлдэгдэл энэ нутагт төвхнүүлэгдэх болно; мөн энэ нь тэдний өвийн нутаг байх болно; мөн тэд, эртний Иерусалимын адилаар, Их Эзэний тулд ариун хот босгох болно; мөн дэлхий эцэслэх үед ирэх тэрхүү төгсгөл хүртэл тэд дахин бусниулагдахгүй.

## Ether 13

And now I, Moroni, proceed to finish my record concerning the destruction of the people of whom I have been writing.

For behold, they rejected all the words of Ether; for he truly told them of all things, from the beginning of man; and that after the waters had receded from off the face of this land it became a choice land above all other lands, a chosen land of the Lord; wherefore the Lord would have that all men should serve him who dwell upon the face thereof;

And that it was the place of the New Jerusalem, which should come down out of heaven, and the holy sanctuary of the Lord.

Behold, Ether saw the days of Christ, and he spake concerning a New Jerusalem upon this land.

And he spake also concerning the house of Israel, and the Jerusalem from whence Lehi should come—after it should be destroyed it should be built up again, a holy city unto the Lord; wherefore, it could not be a new Jerusalem for it had been in a time of old; but it should be built up again, and become a holy city of the Lord; and it should be built unto the house of Israel—

And that a New Jerusalem should be built up upon this land, unto the remnant of the seed of Joseph, for which things there has been a type.

For as Joseph brought his father down into the land of Egypt, even so he died there; wherefore, the Lord brought a remnant of the seed of Joseph out of the land of Jerusalem, that he might be merciful unto the seed of Joseph that they should perish not, even as he was merciful unto the father of Joseph that he should perish not.

Wherefore, the remnant of the house of Joseph shall be built upon this land; and it shall be a land of their inheritance; and they shall build up a holy city unto the Lord, like unto the Jerusalem of old; and they shall no more be confounded, until the end come when the earth shall pass away.

- 9 Мөн шинэ тэнгэр мөн шинэ дэлхий байх болно; мөн тэдгээр нь хуучин нь эцэслэж, мөн бүх зүйл шинэ болсноос бусдаар хуучинтайгаа адил байх болно.
- 10 Мөн тэгээд Шинэ Иерусалим ирнэ; мөн тэнд оршин суух тэд адислагдсан болой, учир нь Хурганы цусаар өмсгөлүүд нь цагаан болгогдсон нь тэд юм; мөн тэд бол Израилын угсааных болох, Иосефын үр удмын үлдэгдэл дунд тоологдох тэд юм.
- 11 Мөн тэгээд түүнчлэн хуучны Иерусалим ирэх болно; мөн түүний оршин суугчид, тэд адислагдсан болой, учир нь тэд Хурганы цусанд угаагдсан юм; мөн тэд бол тараагдаж мөн дэлхийн дөрвөн зүгээс, мөн умард улсуудаас цуглуулагдсан, мөн Бурхан тэдний эцэг Абрахамтай хийсэн гэрээний биелэлтийг хүртэгсэд болох тэд юм.
- 12 Мөн эдгээр зүйлс ирэхдээ, эхэнд байсан, эцэст байх тэд гэж бий; мөн эцэст байсан, эхэнд байх тэд гэж бий хэмээн өгүүлэх судрыг улиран тохиолгох буюу.
- 13 Мөн би илүүг бичихээр зэхэж байв, гэвч би хориглогдсон юм; гэвч Иферийн бошиглолууд агуу хийгээд гайхамшигтай байсан бөлгөө; гэвч тэд түүнийг юу ч биш мэт үнэлсэн, мөн түүнийг хөөн зайлуулсан; мөн тэрээр өдөр нь өөрийгөө хадан агуйд нууж, мөн шөнө нь тэрээр явж хүмүүсийн дээр тохиох зүйлийг хардаг байв.
- 14 Мөн хүмүүсийн дээр ирсэн устгалуудыг шөнөөр хараад, тэрээр хадан агуйд амьдарч байхдаа тэрээр энэхүү цэдгийн үлдэгдлийг хийсэн ажээ.
- 15 Мөнхүү улиран тохиох дор тэрээр хүмүүсийн дундаас зайлуулагдсан тэр жил хүмүүсийн дунд агуу дайн эхлэв, учир нь боссон нь, мөн урьд яригдаж асан тэдний ёс бусын үйлийн нууц төлөвлөгөөгөөр Кориантумыг устгахаар эрэлхийлж байсан нь олон байв, мөн тэдгээр нь хүчит эрчүүд байв.
- 16 Мөн эдүгээ Кориантумр, өөрөө дайны бүх аргад мөн дэлхийн бүх башир аргад суралцжээ, иймийн тул өөрийг нь устгахаар эрэлхийлсэн тэдэнтэй тэр тулаанд оров.

And there shall be a new heaven and a new earth; and they shall be like unto the old save the old have passed away, and all things have become new.

And then cometh the New Jerusalem; and blessed are they who dwell therein, for it is they whose garments are white through the blood of the Lamb; and they are they who are numbered among the remnant of the seed of Joseph, who were of the house of Israel.

And then also cometh the Jerusalem of old; and the inhabitants thereof, blessed are they, for they have been washed in the blood of the Lamb; and they are they who were scattered and gathered in from the four quarters of the earth, and from the north countries, and are partakers of the fulfilling of the covenant which God made with their father, Abraham.

And when these things come, bringeth to pass the scripture which saith, there are they who were first, who shall be last; and there are they who were last, who shall be first.

And I was about to write more, but I am forbidden; but great and marvelous were the prophecies of Ether; but they esteemed him as naught, and cast him out; and he hid himself in the cavity of a rock by day, and by night he went forth viewing the things which should come upon the people.

And as he dwelt in the cavity of a rock he made the remainder of this record, viewing the destructions which came upon the people, by night.

And it came to pass that in that same year in which he was cast out from among the people there began to be a great war among the people, for there were many who rose up, who were mighty men, and sought to destroy Coriantumr by their secret plans of wickedness, of which hath been spoken.

And now Coriantumr, having studied, himself, in all the arts of war and all the cunning of the world, wherefore he gave battle unto them who sought to destroy him.



17 Гэвч, тэрбээр наманчилсан нь үгүй, бас түүний хонгорхон охид мөн хөвгүүд ч тэгсэнгүй; мөн Кохорын хонгорхон охид мөн хөвгүүд ч тэгсэнгүй; Корихорын хонгорхон охид мөн хөвгүүд ч тэгсэнгүй; мөн эцэст нь бүх дэлхийн гадаргуу дээр нүглүүдээ наманчилсан хонгорхон охид мөн хөвгүүд нэг ч байсангүй.

18 Иймийн тул, улиран тохиох дор Ифер хадан агуйд оршин суусан эхний жилд, тэд хаант улсыг олж авахын тулд Кориантумын эсрэг тулалдаж асан тэдгээр нууц хуйвалдаануудын илдээр хөнөөгдсөн нь олон байв.

19 Мөнхүү улиран тохиох дор Кориантумын хөвгүүд их тулалдаж мөн их цус урсав.

20 Мөн хоёр дахь жилд Их Эзэний үг Иферт ирж, хэрэв тэрбээр мөн түүний бүх гэр бүлийнхэн наманчлах аваас, Их Эзэн түүнд хаант улсыг нь өгч мөн уг хүмүүсийг хэлтрүүлэх болохыг тэрбээр явж мөн, Кориантумрт ийн бошиглохыг хэлэв—

21 Эс бөгөөс тэд, мөн түүнээс бусад бүх л гэр бүлийнхэн нь устгагдах болно. Мөн тэдний өвийн нутгийг хүлээн авах талаар хэлэгдсэн бошиглолын биелэлийг зөвхөн үзэхийн тулд тэрбээр өөр хүмүүс амьд үлдэх болно; мөн Кориантумр тэднээр оршуулагдах болно; мөн Кориантумраас бусад бүх бодгаль устгагдах болно.

22 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр, түүний гэр бүлийнхэн ч бас наманчилсангүй, мөн уг хүмүүс ч бас тэгсэнгүй; мөн дайнууд зогссонгүй; мөн тэд Иферийг алахыг эрэлхийлэв, гэвч тэрээр тэдний өмнө зугтан мөн дахин хадан агуйд нуугдав.

23 Мөнхүү улиран тохиох дор Шаред босч, мөн тэрээр Кориантумртай тулаанд оров; мөн тэрбээр түүнийг дийлж, үүний хэрээр гурав дахь жилд тэрбээр түүнийг боолчлолд оруулав.

24 Мөн Кориантумын хөвгүүд, дөрөв дэх жилд, Шаредийг дийлж, мөн эцэгтээ хаант улсыг нь буцаан авч өгсөн бөлгөө.

25 Эдүгээ нутгийн бүх гадаргуу дээр дайн эхлэв, хүмүүн бүр бүлэглэлийнхээ хамт хүссэнийхээ төлөө дайтах ажгуу.

26 Мөн дээрэмчид байв, мөн эцэст нь, нутгийн бүх гадаргуу дээр бүх төрлийн ёс бусын үйл байв.

But he repented not, neither his fair sons nor daughters; neither the fair sons and daughters of Cohor; neither the fair sons and daughters of Corihor; and in fine, there were none of the fair sons and daughters upon the face of the whole earth who repented of their sins.

Wherefore, it came to pass that in the first year that Ether dwelt in the cavity of a rock, there were many people who were slain by the sword of those secret combinations, fighting against Coriantumr that they might obtain the kingdom.

And it came to pass that the sons of Coriantumr fought much and bled much.

And in the second year the word of the Lord came to Ether, that he should go and prophesy unto Coriantumr that, if he would repent, and all his household, the Lord would give unto him his kingdom and spare the people—

Otherwise they should be destroyed, and all his household save it were himself. And he should only live to see the fulfilling of the prophecies which had been spoken concerning another people receiving the land for their inheritance; and Coriantumr should receive a burial by them; and every soul should be destroyed save it were Coriantumr.

And it came to pass that Coriantumr repented not, neither his household, neither the people; and the wars ceased not; and they sought to kill Ether, but he fled from before them and hid again in the cavity of the rock.

And it came to pass that there arose up Shared, and he also gave battle unto Coriantumr; and he did beat him, insomuch that in the third year he did bring him into captivity.

And the sons of Coriantumr, in the fourth year, did beat Shared, and did obtain the kingdom again unto their father.

Now there began to be a war upon all the face of the land, every man with his band fighting for that which he desired.

And there were robbers, and in fine, all manner of wickedness upon all the face of the land.

27 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр Шаредад үлэмж хилэгнэн, мөн тэрбээр түүний эсрэг их цэрэгтэйгээ тулалдаанд явав; мөн тэд агуу хилэнтэйгээр тулгарч, мөн тэд Гилгалын хөндийд тулгарсан бөлгөө; мөн тулалдаан үлэмж ширүүн болов.

28 Мөнхүү улиран тохиох дор Шаред түүний эсрэг гурван өдрийн турш тулалдсан аж. Мөнхүү улиран тохиох дор Кориантумр түүнийг дийлж, мөн тэрбээр Хешлоны тал газруудад ирэх хүртэл түүнийг үлдэн хөөв.

29 Мөнхүү улиран тохиох дор Шаред тал газруудад түүнтэй дахин тулалдаанд оров; мөн болгоогтун, тэр Кориантумрыг дийлж, мөн түүнийг Гилгалын хөндийд ортол нь гэдрэг ухраав.

30 Мөн Гилгалын хөндийд Кориантумр дахин Шаредтай тулалдаанд оров, тэгснээр Шаредыг дийлж мөн түүнийг хөнөөв.

31 Мөн Шаред Кориантумрыг гуянд нь шархдуулснаас, тийнхүү тэр хоёр жилийн турш дахин тулалдахаар явсангүй, тэр хугацаанд нутгийн гадаргуу дээрх бүх хүмүүс цус урсгаж, мөн тэднийг зогсоох хэн ч үгүй байв.

And it came to pass that Coriantumr was exceedingly angry with Shared, and he went against him with his armies to battle; and they did meet in great anger, and they did meet in the valley of Gilgal; and the battle became exceedingly sore.

And it came to pass that Shared fought against him for the space of three days. And it came to pass that Coriantumr beat him, and did pursue him until he came to the plains of Heshlon.

And it came to pass that Shared gave him battle again upon the plains; and behold, he did beat Coriantumr, and drove him back again to the valley of Gilgal.

And Coriantumr gave Shared battle again in the valley of Gilgal, in which he beat Shared and slew him.

And Shared wounded Coriantumr in his thigh, that he did not go to battle again for the space of two years, in which time all the people upon the face of the land were shedding blood, and there was none to restrain them.

## Ифер 14

- 1 Мөн эдүгээ бүх нутагт хүмүүсийн алдсын улмаас агуу зүхэл байж эхлэв, тэгснээр, хэрэв хүмүүн өөрийн багаж эсвээс илдээ тавиур дээрээ, эсвээс тэрбээр үүнийг хаа хадгалах тэр газраа тавих аваас, болгоогтун, маргааш өдөр нь тэрбээр үүнийг олж чадахгүй байв, уг нутгийн дээрх зүхэл тийм агуу байв.
- 2 Иймийн тул хүмүүн бүр өөрийнх болох түүнийг, гартаа чанга атгаж, мөн зээлэхгүй бас зээлүүлэхгүй байв; мөн хүмүүн бүр, өөрийн өмч болон өөрийн эхнэр мөн хүүхдүүдийнхээ амийг хамгаалахын тулд, илднийхээ бариулыг баруун гартаа атгаж байв.
- 3 Мөн эдүгээ, хоёр жилийн дараа, мөн Шаредын үхлийн дараа, болгоогтун, Шаредын дүү босож мөн тэрбээр Кориантумртай тулалдаанд оров, түүгээр Кориантумр түүнийг дийлж мөн Акишийн аглаг буйд хүртэл түүнийг үлдэн хөөв.
- 4 Мөнхүү улиран тохиох дор Шаредын дүү Акишийн аглаг буйдад түүнтэй тулалдаанд орсон аж; мөн тулалдаан үлэмж ширүүн болж, мөн олон мянга нь илдээр унагаагдав.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр аглаг буйдад бүслэн хаав; мөн Шаредын дүү шөнөөр аглаг буйдаас алхан гарч, мөн тэднийг согтуу байхад нь, Кориантумрын цэргүүдийн хэсгийг хөнөөв.
- 6 Мөн тэрбээр Мороны нутагт ирж, мөн Кориантумрын хаан сэнтийд өөрийгөө залав.
- 7 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр өөрийн их цэрэгтэй аглаг буйдад хоёр жилийн турш оршин суув, ингэснээр тэрбээр өөрийн их цэрэгт агуу нэмэлт хүч хүлээн авчээ.
- 8 Эдүгээ, нэр нь Гилиад болох, Шаредын дүү, нууц хуйвалдааны улмаас, их цэрэгтээ агуу нэмэлт хүч хүлээн авсан ажгуу.
- 9 Мөнхүү улиран тохиох дор түүнийг тэрбээр хаан сэнтийд заларч байхад нь дээд санваартан нь түүнийг хөнөөв.
- 10 Мөнхүү улиран тохиох дор нууц хуйвалдагчдын нэг түүнийг нууц гарцанд хөнөөв, мөн өөртөө хаант улсыг олж авав; мөн түүний нэр Либ байлаа; мөн Либ, бүх хүмүүсийн дундах аливаа бусад эрчүүдээс илүү агуу том биетэй хүн байв.

## Ether 14

And now there began to be a great curse upon all the land because of the iniquity of the people, in which, if a man should lay his tool or his sword upon his shelf, or upon the place whither he would keep it, behold, upon the morrow, he could not find it, so great was the curse upon the land.

Wherefore every man did cleave unto that which was his own, with his hands, and would not borrow neither would he lend; and every man kept the hilt of his sword in his right hand, in the defence of his property and his own life and of his wives and children.

And now, after the space of two years, and after the death of Shared, behold, there arose the brother of Shared and he gave battle unto Coriantumr, in which Coriantumr did beat him and did pursue him to the wilderness of Akish.

And it came to pass that the brother of Shared did give battle unto him in the wilderness of Akish; and the battle became exceedingly sore, and many thousands fell by the sword.

And it came to pass that Coriantumr did lay siege to the wilderness; and the brother of Shared did march forth out of the wilderness by night, and slew a part of the army of Coriantumr, as they were drunken.

And he came forth to the land of Moron, and placed himself upon the throne of Coriantumr.

And it came to pass that Coriantumr dwelt with his army in the wilderness for the space of two years, in which he did receive great strength to his army.

Now the brother of Shared, whose name was Gilead, also received great strength to his army, because of secret combinations.

And it came to pass that his high priest murdered him as he sat upon his throne.

And it came to pass that one of the secret combinations murdered him in a secret pass, and obtained unto himself the kingdom; and his name was Lib; and Lib was a man of great stature, more than any other man among all the people.

11 Мөнхүү улиран тохиох дор Либийн эхний жилд, Кориантумр Мороны нутагт өгсөн ирж, мөн Либтэй тулалдаанд оров.

12 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Либтэй тулалдаж, тэгснээр Либ түүний гарыг цохьсноос тэрбээр шархдав; гэсэн хэдий ч, Кориантумрын их цэрэг Либийг довтлон шахсанаас, тэрбээр тэнгисийн эргийн хил тийш зугтсан ажээ.

13 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр түүнийг үлдэн хөөв; мөн Либ тэнгисийн эрэг дээр түүнтэй тулалдаанд оров.

14 Мөнхүү улиран тохиох дор Либ Кориантумрын их цэргийг дийлснээс, тэд дахин Акишийн аглаг буйд хүртэл зугтсан болой.

15 Мөнхүү улиран тохиох дор Либ түүнийг Агошийн тал газар очих хүртэл үлдэн хөөв. Мөн Коринтумр Либийн өмнө зугтаж явахдаа зугтан очсон уг нутгийн тэр хэсгийн бүх хүмүүсийг авч явав.

16 Мөн тэрбээр Агошийн тал газарт ирээд Либтэй тулалдаанд орж, мөн тэрбээр түүнийг үхтэл нь цохьсон ажгуу; гэсэн хэдий ч, Либийн дүү түүний оронд Кориантумрын эсрэг ирж, мөн уг тулалдаан үлэмж ширүүн болов, үүнд Кориантумр дахин Либийн дүүгийн их цэргийн өмнө зугтав.

17 Эдүгээ Либийн дүүгийн нэр нь Шиз хэмээгддэг байв. Мөнхүү улиран тохиох дор Шиз Кориантумрын араас үлдэн хөөж, мөн тэрбээр олон хотыг эзлэн авч, мөн тэрбээр эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийг түүнчлэн хөнөөж, мөн тэрбээр хотуудыг шатаасан ажээ.

18 Мөн бүх нутгаар Шизээс эмээх айдас тархав; тийм ээ, нутаг даяар нэг шуугиан тархав—Хэн Шизийн их цэргийн өмнө зогсож чадах билээ? Болгоогтун, тэрбээр өмнөө буй газар дэлхийг хүйс тэмтэрч байна!

19 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс, нутгийн бүх гадаргуу даяар, их цэрэгт нэгдэн цугларч эхлэв.

20 Мөн тэд хуваагдсан байлаа; мөн тэдний нэг хэсэг нь Шизийн их цэрэгт зугтан очиж, мөн тэдний нэг хэсэг нь Кориантумрын их цэрэгт зугтан очив.

21 Мөн уг нутгийн бүх гадаргуу үхэгсдийн хүүрээр бүрхэгдэхээр, дайн тийм агуу хийгээд удаан болж, мөн удаан хугацааны турш урсах цус болоод хядааны талбар байв.

And it came to pass that in the first year of Lib, Coriantumr came up unto the land of Moron, and gave battle unto Lib.

And it came to pass that he fought with Lib, in which Lib did smite upon his arm that he was wounded; nevertheless, the army of Coriantumr did press forward upon Lib, that he fled to the borders upon the seashore.

And it came to pass that Coriantumr pursued him; and Lib gave battle unto him upon the seashore.

And it came to pass that Lib did smite the army of Coriantumr, that they fled again to the wilderness of Akish.

And it came to pass that Lib did pursue him until he came to the plains of Agosh. And Coriantumr had taken all the people with him as he fled before Lib in that quarter of the land whither he fled.

And when he had come to the plains of Agosh he gave battle unto Lib, and he smote upon him until he died; nevertheless, the brother of Lib did come against Coriantumr in the stead thereof, and the battle became exceedingly sore, in the which Coriantumr fled again before the army of the brother of Lib.

Now the name of the brother of Lib was called Shiz. And it came to pass that Shiz pursued after Coriantumr, and he did overthrow many cities, and he did slay both women and children, and he did burn the cities.

And there went a fear of Shiz throughout all the land; yea, a cry went forth throughout the land—Who can stand before the army of Shiz? Behold, he sweepeth the earth before him!

And it came to pass that the people began to flock together in armies, throughout all the face of the land.

And they were divided; and a part of them fled to the army of Shiz, and a part of them fled to the army of Coriantumr.

And so great and lasting had been the war, and so long had been the scene of bloodshed and carnage, that the whole face of the land was covered with the bodies of the dead.

- 22 Мөн нас барагсдаа оршуулах хэн ч үлдсэнгүй, дайн тийм яаруу мөн хурдтай байж, харин тэд, уг нутгийн гадаргуу дээр тархсан эрчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүдийн хүүрийг махны өт хорхойд улай болгохоор орхин, цус урсгалтаас цус урсгалтанд жагсан явж байлаа.
- 23 Мөн үүний үнэр нутгийн бүх гадаргуу дээр, бүр бүх нутгийн гадаргуу дээр тархсан байлаа; иймийн тул үүний үнэрийн улмаас, хүмүүс өдрөөр мөн шөнөөр балмагдсан байв.
- 24 Гэсэн хэдий ч, Шиз Кориантумрыг үлдэн хөөхөө зогссонгүй; учир нь, Кориантумр илдээр унагаагдахгүй хэмээн Иферт ирсэн Их Эзэний үгний улмаас, мөн хөнөөгдсөн ахынхаа цусны өшөөг Кориантумраас авахаар тэрээр өөртөө тангарагласан байв.
- 25 Мөн тийн Их Эзэн тэдэнд өөрийн бүрэн хилэнгээр зочилж, мөн тэдний ёс бус үйл мөн жигшүүрт хэргүүд тэднийг үүрдийн устгалд хүрэх замыг бэлтгэснийг бид харав.
- 26 Мөнхүү улиран тохиох дор Шиз Кориантумрыг дорно зүг тийш, бүр тэнгисийн эргийн дэргэдэх хязгаарыг хүртэл хөөж, мөн тэрээр гурван өдрийн турш тэнд Шизтэй тулалдаанд оров.
- 27 Мөн хүмүүс айж эхлэн, мөн Кориантумрын их цэргийн өмнө зугтаж эхлэхээр Шизийн их цэргийн дундах устгал тийм аймшигтай байв; мөн тэд Корихорын нутагт зугтан, мөн тэдний өмнөх оршин суугчдыг, тэдэнтэй нэгдэхээс татгалзсан бүгдийг хүйс тэмтрэв.
- 28 Мөн тэд Корихорын хөндийд майхнуудаа босгов; мөн Кориантумр майхнуудаа Шуррын хөндийд босгов. Эдүгээ Шуррын хөндий Комнорын толгойн ойр байв; иймийн тул, Кориантумр их цэргээ Комнорын толгод дээр цуглуулж, мөн Шизийн их цэрэгт, тэднийг тулалдаанд дуудахаар бүрээ үлээв.
- 29 Мөнхүү улиран тохиох дор тэд хүрч ирж, гэвч гэдрэг ухраагдав; мөн тэд хоёр дахь удаагаа ирж, мөн тэд буцаан хоёр дахь удаагаа гэдрэг ухраагдсан бөлгөө. Мөнхүү улиран тохиох дор тэд дахин гурав дахь удаагаа ирж, мөн тулалдаан үлэмж ширүүн болов.

And so swift and speedy was the war that there was none left to bury the dead, but they did march forth from the shedding of blood to the shedding of blood, leaving the bodies of both men, women, and children strewn upon the face of the land, to become a prey to the worms of the flesh.

And the scent thereof went forth upon the face of the land, even upon all the face of the land; wherefore the people became troubled by day and by night, because of the scent thereof.

Nevertheless, Shiz did not cease to pursue Coriantumr; for he had sworn to avenge himself upon Coriantumr of the blood of his brother, who had been slain, and the word of the Lord which came to Ether that Coriantumr should not fall by the sword.

And thus we see that the Lord did visit them in the fulness of his wrath, and their wickedness and abominations had prepared a way for their everlasting destruction.

And it came to pass that Shiz did pursue Coriantumr eastward, even to the borders by the seashore, and there he gave battle unto Shiz for the space of three days.

And so terrible was the destruction among the armies of Shiz that the people began to be frightened, and began to flee before the armies of Coriantumr; and they fled to the land of Corihor, and swept off the inhabitants before them, all them that would not join them.

And they pitched their tents in the valley of Corihor; and Coriantumr pitched his tents in the valley of Shurr. Now the valley of Shurr was near the hill Comnor; wherefore, Coriantumr did gather his armies together upon the hill Comnor, and did sound a trumpet unto the armies of Shiz to invite them forth to battle.

And it came to pass that they came forth, but were driven again; and they came the second time, and they were driven again the second time. And it came to pass that they came again the third time, and the battle became exceedingly sore.

30 Мөнхүү улиран тохиох дор Шиз Кориантумыг цохьсноос түүнийг олон гүн шархтай болгосон аж; мөн Кориантумр, цус алдсанаас, ухаан алдан, мөн тэрээр үхсэн мэт өргүүлэн хүргэгджээ.

31 Эдүгээ Кориантумын их цэргийг үлдэн хөөхгүй байхыг Шиз өөрийн хүмүүст зарлиглахуйц, аль аль талд нь эрчүүд, эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн алдал тийм агуу байв; иймийн тул, тэд буудалдаа буцав.

And it came to pass that Shiz smote upon Coriantumr that he gave him many deep wounds; and Coriantumr, having lost his blood, fainted, and was carried away as though he were dead.

Now the loss of men, women and children on both sides was so great that Shiz commanded his people that they should not pursue the armies of Coriantumr; wherefore, they returned to their camp.

## Ифер 15

- 1 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр шархнаасаа эдгээд, тэрбээр өөрт нь хандан Иферийн хэлсэн үгсийг санаж эхлэв.
- 2 Тэрбээр хэдийн өөрсдийнх нь хоёр сая шахам хүмүүс илдээр хөнөөгдсөнийг харж, мөн тэрбээр зүрх сэтгэлдээ гашуудаж эхлэв; тийм ээ, хүчит эрчүүд, мөн түүнчлэн тэдний эхнэрүүд, мөн тэдний хүүхдүүдээс хоёр сая нь хөнөөгдсөн байв.
- 3 Тэрбээр хилэнцээ наманчилж эхлэв; тэрбээр бүх бошиглогчдын амаар хэлэгдсэн үгсийг санаж эхлэв, мөн тэрбээр, тэдгээр нь өдийг хүртэл, нэг бүрчлэн биелэгдсэнийг ухаарав; мөн түүний сэтгэл гашуудан мөн тайтгаруулагдахаас татгалзав.
- 4 Мөнхүү улиран тохиох дор, тэрбээр хүмүүсийг хэлтрүүлэх аваас, хүмүүсийн амийн төлөө тэрбээр хаант улсаа өгөх болно хэмээн хүсч тэрбээр Шизэд захидал бичив.
- 5 Мөнхүү улиран тохиох дор Шиз түүний захидлыг хүлээн аваад тэрбээр, хэрэв тэрбээр түүнийг өөрийнх нь илдээр хөнөөж болохын тулд тэрбээр өөрийгөө өгөх аваас, хүмүүсийн амийг тэрээр хэлтрүүлэх болно хэмээх захидлыг Кориантумрт бичжээ.
- 6 Мөнхүү улиран тохиох дор хүмүүс алдсаа наманчилсангүй; мөн Кориантумрын хүмүүс Шизийн хүмүүсийн эсрэг уур хилэнд өдөөн хатгагдав; мөн Шизийн хүмүүс Кориантумрын хүмүүсийн эсрэг уур хилэнд өдөөн хатгагдав; иймийн тул, Шизийн хүмүүс Кориантумрын хүмүүсийн эсрэг тулалдаанд оров.
- 7 Мөн Кориантумр унах гэж буйгаа үзээд тэрбээр Шизийн хүмүүсийн өмнө дахин зугтав.
- 8 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр, хөрвүүлбээс том, эсвэл бүгдээс нэт гэгдэх, Риплианкумын усанд ирэв; иймийн тул, тэд энэ усанд ирээд майхнуудаа босгов; мөн Шиз түүнчлэн тэдэнд ойрхон майхнуудаа босгов, мөн тиймийн тул маргааш нь тэд тулалдаанд оров.
- 9 Мөнхүү улиран тохиох дор тэд үлэмж ширүүн тулалдаанд тулалдаж, тэгснээр Кориантумр дахин шархдаж, мөн тэрбээр цус алдсанаас ухаан алдав.

## Ether 15

And it came to pass when Coriantumr had recovered of his wounds, he began to remember the words which Ether had spoken unto him.

He saw that there had been slain by the sword already nearly two millions of his people, and he began to sorrow in his heart; yea, there had been slain two millions of mighty men, and also their wives and their children.

He began to repent of the evil which he had done; he began to remember the words which had been spoken by the mouth of all the prophets, and he saw them that they were fulfilled thus far, every whit; and his soul mourned and refused to be comforted.

And it came to pass that he wrote an epistle unto Shiz, desiring him that he would spare the people, and he would give up the kingdom for the sake of the lives of the people.

And it came to pass that when Shiz had received his epistle he wrote an epistle unto Coriantumr, that if he would give himself up, that he might slay him with his own sword, that he would spare the lives of the people.

And it came to pass that the people repented not of their iniquity; and the people of Coriantumr were stirred up to anger against the people of Shiz; and the people of Shiz were stirred up to anger against the people of Coriantumr; wherefore, the people of Shiz did give battle unto the people of Coriantumr.

And when Coriantumr saw that he was about to fall he fled again before the people of Shiz.

And it came to pass that he came to the waters of Ripliancum, which, by interpretation, is large, or to exceed all; wherefore, when they came to these waters they pitched their tents; and Shiz also pitched his tents near unto them; and therefore on the morrow they did come to battle.

And it came to pass that they fought an exceedingly sore battle, in which Coriantumr was wounded again, and he fainted with the loss of blood.

10 Мөнхүү улиран тохиох дор Кориантумрын их цэрэг Шизийн их цэргийг довтлон шахсанаас, тэднийг дийлж, тэднийг өөрсдийн өмнө зугтах болгов; мөн тэд өмнө зүг зугтаж, мөн Огаф хэмээн нэрлэгдэх газар майхнуудаа босгов.

11 Мөнхүү улиран тохиох дор Кориантумрын их цэрэг Рама толгойн хажууд майхнуудаа босгов; мөн миний эцэг Мормон ариун нандин цэдгүүдийг Их Эзэний тулд нуусан тэрхүү толгой бөлгөө.

12 Мөнхүү улиран тохиох дор тэд нутгийн бүх гадаргуу дээрх, хөнөөгдөөгүй асан, Иферээс бусад бүх хүмүүсийг нэгтгэн цуглуулав.

13 Мөнхүү улиран тохиох дор Ифер хүмүүсийн бүх үйлдлийг харсан аж; мөн Кориантумрын талд байсан хүмүүс Кориантумрын их цэрэгт нэгдэн цугларсныг; мөн Шизийн талд байсан хүмүүс Шизийн их цэрэгт нэгдэн цугларсныг тэрээр болгоов.

14 Иймийн тул, тэд уг нутгийн гадаргуу дээр байсан бүгдийг авч болохын тулд, мөн тэд хүлээн авч болох бүх нэмэлт хүчийг тэд хүлээн авч болохын тулд, тэд дөрвөн жилийн турш хүмүүсийг нэгтгэн цуглуулж байв.

15 Мөнхүү улиран тохиох дор тэд бүгдээрээ, хүн бүр дуртай их цэрэгтээ, эхнэр мөн хүүхдүүдтэйгээ нэгдэн цугларсны дараа—эрчүүд, эмэгтэйчүүд мөн хүүхдүүд аль аль нь дайны зэвсгээр зэвсэглэн, бамбай, мөн цээжний хуяг, мөн толгойн дуулга агсан, мөн дайны байдлаар хувцаслан—тэд нэг нэгнийхээ эсрэг тулалдахаар давшив; мөн тэд тэр өдөржингөө дайтав, мөн ялсан нь үгүй.

16 Мөнхүү улиран тохиох дор шөнө болоход тэд ядарч, мөн буудлууддаа гэдрэг ухрав; мөн буудалдаа ухарсны дараа тэд өөрсдийн хүмүүсээс алагдагсдын хохирлын учир орь дуу тавин мөн гаслав; мөн тэд агаарыг үлэмж доргиохоор тэдний уйлаан, тэдний орь дуу тавилт гаслан хийгээд тийм агуу байв.

17 Мөнхүү улиран тохиох дор маргааш нь тэд дахин тулалдахаар явж, мөн тэр өдөр агуу хийгээд аймшигтай байсан ажгуу; гэсэн хэдий ч, тэд ялсангүй, мөн дахин шөнө ирэхэд тэд өөрсдийн хүмүүсээс алагдагсдын хохирлын учир, тэд уйлаан, мөн орь дуу тавилт, мөн гаслангаараа агаарыг доргиов.

And it came to pass that the armies of Coriantumr did press upon the armies of Shiz that they beat them, that they caused them to flee before them; and they did flee southward, and did pitch their tents in a place which was called Ogath.

And it came to pass that the army of Coriantumr did pitch their tents by the hill Ramah; and it was that same hill where my father Mormon did hide up the records unto the Lord, which were sacred.

And it came to pass that they did gather together all the people upon all the face of the land, who had not been slain, save it was Ether.

And it came to pass that Ether did behold all the doings of the people; and he beheld that the people who were for Coriantumr were gathered together to the army of Coriantumr; and the people who were for Shiz were gathered together to the army of Shiz.

Wherefore, they were for the space of four years gathering together the people, that they might get all who were upon the face of the land, and that they might receive all the strength which it was possible that they could receive.

And it came to pass that when they were all gathered together, every one to the army which he would, with their wives and their children—both men, women and children being armed with weapons of war, having shields, and breastplates, and head-plates, and being clothed after the manner of war—they did march forth one against another to battle; and they fought all that day, and conquered not.

And it came to pass that when it was night they were weary, and retired to their camps; and after they had retired to their camps they took up a howling and a lamentation for the loss of the slain of their people; and so great were their cries, their howlings and lamentations, that they did rend the air exceedingly.

And it came to pass that on the morrow they did go again to battle, and great and terrible was that day; nevertheless, they conquered not, and when the night came again they did rend the air with their cries, and their howlings, and their mournings, for the loss of the slain of their people.



18 Мөнхүү улиран тохиох дор, тэрбээр дахин тулалдаанд орохгүй, харин тэрбээр хаант улсыг авч, мөн хүмүүсийнх нь амийг хэлтрүүлээч хэмээн хүссэн захидлыг Шизэд Кориантумр бичив.

19 Гэвч болгоогтун, Их Эзэний Сүнс тэдний төлөө зүтгэхээ больсон байв, мөн Сатан хүмүүсийн зүрх сэтгэлийн дээр бүрэн хүчийг агуулж байв; учир нь тэд өөрсдөө устгагдаж болохын тулд зүрх сэтгэлийнхээ хатууд, мөн оюун санааныхаа харалганд автагдсан байв; иймийн тул тэд дахин тулалдахаар явав.

20 Мөнхүү улиран тохиох дор тэд өдөржингөө тулалдан, мөн шөнө ирэхэд тэд илдээ дэрлэн унтацгаав.

21 Мөн маргааш нь тэд бүр шөнө ирэх хүртэл тулалдав.

22 Мөн шөнө ирэхэд тэд уур хилэндээ, бүр дарсанд согтуурсан хүмүүний адилаар согтсон байв; мөн тэд дахин илдээ дэрлэн унтацгаав.

23 Мөн маргааш нь тэд дахин тулалдав; мөн шөнө ирэхэд тэд Кориантумрын хүмүүсээс тавин хоёр, мөн Шизийн хүмүүсээс жаран есөөс бусад нь бүгд илдээр унагаагдсан байв.

24 Мөнхүү улиран тохиох дор тэр шөнөдөө тэд илдээ дэрлэн унтаж, мөн маргааш нь тэд дахин тулалдав, мөн тэд өөрсдийн илдтэйгээр мөн өөрсдийн бамбайтайгаар, тэр өдөржингөө бүх хүчээрээ тэмцэлдэв.

25 Мөн шөнө ирэхэд Шизийн хүмүүсээс гучин хоёр, мөн Кориантумрын хүмүүсээс хорин долоо нь үлдсэн байв.

26 Мөнхүү улиран тохиох дор тэд идээд мөн унтав, мөн маргааш болох үхэлд бэлтгэцгээв. Мөн тэд хүмүүний хүч тэнхээний хувьд том биетэй мөн хүчит эрчүүд байв.

27 Мөнхүү улиран тохиох дор тэд гурван цагийн турш тулалдаж, мөн тэд цус алдан ухаан алдацгаав.

28 Мөнхүү улиран тохиох дор Кориантумрын хүмүүс тэд алхаж чадах хангалттай хүч тамиртай болоод, тэд амиа хоохойлон зугтахаар завдаж байв; гэвч болгоогтун, Шиз, мөн түүний хүмүүс босон, мөн тэрээр Кориантумрыг хөнөөнө эс бөгөөс өөрөө илдэнд үхнэ хэмээн тэрбээр уур хилэндээ тангараглав.

And it came to pass that Coriantumr wrote again an epistle unto Shiz, desiring that he would not come again to battle, but that he would take the kingdom, and spare the lives of the people.

But behold, the Spirit of the Lord had ceased striving with them, and Satan had full power over the hearts of the people; for they were given up unto the hardness of their hearts, and the blindness of their minds that they might be destroyed; wherefore they went again to battle.

And it came to pass that they fought all that day, and when the night came they slept upon their swords.

And on the morrow they fought even until the night came.

And when the night came they were drunken with anger, even as a man who is drunken with wine; and they slept again upon their swords.

And on the morrow they fought again; and when the night came they had all fallen by the sword save it were fifty and two of the people of Coriantumr, and sixty and nine of the people of Shiz.

And it came to pass that they slept upon their swords that night, and on the morrow they fought again, and they contended in their might with their swords and with their shields, all that day.

And when the night came there were thirty and two of the people of Shiz, and twenty and seven of the people of Coriantumr.

And it came to pass that they ate and slept, and prepared for death on the morrow. And they were large and mighty men as to the strength of men.

And it came to pass that they fought for the space of three hours, and they fainted with the loss of blood.

And it came to pass that when the men of Coriantumr had received sufficient strength that they could walk, they were about to flee for their lives; but behold, Shiz arose, and also his men, and he swore in his wrath that he would slay Coriantumr or he would perish by the sword.

29 Иймийн тул, тэрбээр тэднийг хөөж, мөн маргааш өдөр нь тэрбээр тэднийг гүйцэж түүрүүлэв; мөн тэд илдээрээ дахин тулалдав. Мөнхүү улиран тохиох дор тэд, Кориантумр Шиз хоёроос бусад нь бүгд илдээр унагагдсаны дараа, болгоогтун Шиз цус алдан ухаан алджээ.

30 Мөнхүү улиран тохиох дор хэсэг зуур амрахын тулд Кориантумр илдээ налаад, дараа нь тэрбээр Шизийн толгойг тас цавчив.

31 Мөнхүү улиран тохиох дор тэрбээр Шизийн толгойг тас цавчсаны дараа, Шиз гар дээрээ өндийснөө мөн унав; мөн тэрбээр амьсгал авахаар нэг зүтгээд, үхэх нь тэр.

32 Мөнхүү улиран тохиох дор Кориантумр газарт унан, мөн тэрбээр амьгүй мэт болов.

33 Мөн Их Эзэн Иферт хандан ярьж, мөн түүнд хэлрүүн: Гарч явагтун. Мөн тэрбээр гарч яваад, мөн Их Эзэний үгс бүгд биелэгдсэнийг болгоов; мөн тэрбээр цэдгээ дуусгав; (мөн зууны нэгийг нь ч би эс бичсэн буюу) мөн тэрбээр Лимхайн хүмүүс тэдгээрийг олсон тэр байдлаар нь тэдгээрийг нуув.

34 Эдүгээ Иферээр бичигдсэн сүүлчийн үгс нь эдгээр буюу: Их Эзэний гааллаар зөөгдөх үү, эс бөгөөс маханбодид түүний гааллыг тэвчих үү гэдэг нь хамаагүй, бибээр Бурханы хаант улсад аврагдах болтугай. Амен.

Wherefore, he did pursue them, and on the morrow he did overtake them; and they fought again with the sword. And it came to pass that when they had all fallen by the sword, save it were Coriantumr and Shiz, behold Shiz had fainted with the loss of blood.

And it came to pass that when Coriantumr had leaned upon his sword, that he rested a little, he smote off the head of Shiz.

And it came to pass that after he had smitten off the head of Shiz, that Shiz raised up on his hands and fell; and after that he had struggled for breath, he died.

And it came to pass that Coriantumr fell to the earth, and became as if he had no life.

And the Lord spake unto Ether, and said unto him: Go forth. And he went forth, and beheld that the words of the Lord had all been fulfilled; and he finished his record; (and the hundredth part I have not written) and he hid them in a manner that the people of Limhi did find them.

Now the last words which are written by Ether are these: Whether the Lord will that I be translated, or that I suffer the will of the Lord in the flesh, it mattereth not, if it so be that I am saved in the kingdom of God. Amen.

# МОРОНАЙН НОМ

## Моронай 1

- 1 ЭДҮГЭЭ би, Моронай, Жаредын хүмүүсийн шасти-  
рыг хураангуйлахаа төгсгөл болгосныхоо дараа, би  
өөрийг бичнэ хэмээн бодсонгүй, гэвч би хараахан  
мөхөөгүй байна; мөн тэд намайг устгах вий хэмээн  
эмээж би өөрийгөө леменчүүдэд мэдүүлдэггүй.
- 2 Учир нь болгоогтун, өөрсдийнх нь дундах дай-  
нууд үлэмж хэрцгий; мөн тэдний үзэн ядалтын учир  
тэд Христийг үгүйсгэхгүй нифай үндэстэн болгоныг  
үхэлд хүргэдэг.
- 3 Мөн би, Моронай, Христийг үгүйсгэх нь үгүй; ий-  
мийн тул, амь насныхаа аюулгүй байдлын төлөө бо-  
ломжтой хаана ч болов би бэдрэн явдаг.
- 4 Иймийн тул, бодож байсныхаа эсрэгээр өөр цөөн  
хэдэн зүйлийг би бичье; учир нь би илүүг бичих бол-  
но хэмээн бодсонгүй; гэвч Их Эзэний тааллын дагуу,  
ирээдүйн нэг өдөр, леменчүүд, ах дүүст минь чухал  
байж магад хэмээх тул би өөр цөөн хэдэн зүйл бичье.

# The Book of Moroni

## Moroni 1

Now I, Moroni, after having made an end of abridging the account of the people of Jared, I had supposed not to have written more, but I have not as yet perished; and I make not myself known to the Lamanites lest they should destroy me.

For behold, their wars are exceedingly fierce among themselves; and because of their hatred they put to death every Nephite that will not deny the Christ.

And I, Moroni, will not deny the Christ; wherefore, I wander whithersoever I can for the safety of mine own life.

Wherefore, I write a few more things, contrary to that which I had supposed; for I had supposed not to have written any more; but I write a few more things, that perhaps they may be of worth unto my brethren, the Lamanites, in some future day, according to the will of the Lord.

## Моронай 2

- 1 Тэрбээр өөрийн сонгосон тэр арван хоёрын, толгой дээр гараа тавьж, шавь нартаа өгүүлсэн, Христийн үгс оршвой—
- 2 Мөн тэрбээр тэднийг нэрээр нь дуудаж, хэлрүүн: Та нар миний нэрээр, хүчит залбирлаар Эцэгийг дуудах болно; мөн та нар үүнийг хийсний дараа толгой дээр нь гараа тавьсан түүнд та нар Ариун Сүнс өгөх хүчтэй байх болно; мөн миний нэрээр та нар үүнийг өгөх болно, учир нь төлөөлөгчид минь тийн үйлддэг.
- 3 Эдүгээ Христ анхныхаа ирэлтийн үеэр тэдэнд эдгээр үгсийг хэлсэн юм; мөн цугласан олон үүнийг сонссонгүй, гэвч шавь нар нь үүнийг сонссон бөлгөө; мөн тэдний гараа тавьсан болгоны дээр Ариун Сүнс буусан бөлгөө.

## Moroni 2

The words of Christ, which he spake unto his disciples, the twelve whom he had chosen, as he laid his hands upon them—

And he called them by name, saying: Ye shall call on the Father in my name, in mighty prayer; and after ye have done this ye shall have power that to him upon whom ye shall lay your hands, ye shall give the Holy Ghost; and in my name shall ye give it, for thus do mine apostles.

Now Christ spake these words unto them at the time of his first appearing; and the multitude heard it not, but the disciples heard it; and on as many as they laid their hands, fell the Holy Ghost.

## Моронай 3

- 1 Сүмийн ахлагчид хэмээн нэрлэгдсэн тэрхүү шавь нар, санваартнууд болоод багш нарыг томилдог асан тэр маяг нь энэ буюу—
- 2 Тэдгээр нь Христийн нэрээр Эцэгт залбирсны дараа, тэд тэдний дээр гар тавьж мөн хэлэх нь:
- 3 Түүний нэрэнд төгсгөл хүртэл итгэн тэвчсэнээр, Есүс Христээр дамжин ирэх нүглүүдийн ангижрал хийгээд наманчлалыг номлуулахаар би таныг санваартан (эсвээс хэрэв тэр багш байхаар бол, би таныг багш байхаар томилж байна) байхаар Есүс Христийн нэрээр томилж байна. Амен.
- 4 Мөн энэ маягаар тэд санваартнууд болон багш нарыг хүмүүнд өгөгдсөн Бурханы бэлгүүд хийгээд дуудлагуудын дагуу томилдог байв; мөн тэд өөрсдөд нь орших, Ариун Сүнсний хүчээр тэднийг томилдог байв.

## Moroni 3

The manner which the disciples, who were called the elders of the church, ordained priests and teachers—

After they had prayed unto the Father in the name of Christ, they laid their hands upon them, and said:

In the name of Jesus Christ I ordain you to be a priest (or if he be a teacher, I ordain you to be a teacher) to preach repentance and remission of sins through Jesus Christ, by the endurance of faith on his name to the end. Amen.

And after this manner did they ordain priests and teachers, according to the gifts and callings of God unto men; and they ordained them by the power of the Holy Ghost, which was in them.

## Моронай 4

- 1 Ахлагчид болон санваартнууд Сүмийнхэнд Христийн бие болон цусыг адислан түгээх хэлбэр нь; мөн тэд Христийн зарлигуудын дагуу үүнийг адислан түгээдэг байв; иймийн тул бид уг хэлбэр нь үнэнийг мэднэ; мөн ахлагч эсвээс санваартан үүнийг адислан түгээдэг байв—
- 2 Мөн тэд сүмийнхэнтэй хамт сөгдөн сууж, мөн Христийн нэрээр Эцэгт залбирч, хэлдэг байв:
- 3 Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс хүртэх тэд бүгдийн бодгалийн тулд; тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж, тэд үүнийг идэж, Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд өөрсдөдөө таны Хүүгийн нэрийг авч, мөн үргэлж түүнийг санаж, мөн өөрсдөд нь өгсөн түүний зарлигуудыг дагахад бэлэн гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ талхыг адисалж мөн ариусгахыг таны Хүү, Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен.

## Moroni 4

The manner of their elders and priests administering the flesh and blood of Christ unto the church; and they administered it according to the commandments of Christ; wherefore we know the manner to be true; and the elder or priest did minister it—

And they did kneel down with the church, and pray to the Father in the name of Christ, saying:

O God, the Eternal Father, we ask thee in the name of thy Son, Jesus Christ, to bless and sanctify this bread to the souls of all those who partake of it; that they may eat in remembrance of the body of thy Son, and witness unto thee, O God, the Eternal Father, that they are willing to take upon them the name of thy Son, and always remember him, and keep his commandments which he hath given them, that they may always have his Spirit to be with them. Amen.

## Моронай 5

- 1 Дарсыг адислан түгээх хэлбэр нь—Болгоогтун, тэд аяга авч, мөн хэлнэ:
- 2 Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, үүнээс уух тэд бүгдийн бодгалийн тулд, тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгаж болохын тулд, өөрсдийнх нь төлөө асгаруулсан таны Хүүгийн цусыг төлөөлөн дурсаж, тэд үүнийг үйлдэж болохын тулд; Ай Бурхан, Мөнхийн Эцэг минь, тэд үргэлж түүнийг санана гэдгээ танд гэрчилж болохын тулд, энэ дарсыг адисалж, мөн ариулахыг таны Хүү Есүс Христийн нэрээр бид танаас гуйж байна. Амен.

## Moroni 5

The manner of administering the wine—Behold, they took the cup, and said:

O God, the Eternal Father, we ask thee, in the name of thy Son, Jesus Christ, to bless and sanctify this wine to the souls of all those who drink of it, that they may do it in remembrance of the blood of thy Son, which was shed for them; that they may witness unto thee, O God, the Eternal Father, that they do always remember him, that they may have his Spirit to be with them. Amen.

## Моронай 6

- 1 Мөн эдүгээ би баптисмын талаар ярья. Болгоогтун, ахлагч, санваартан мөн багш нар баптисм хүртдэг байв; мөн тэд үүнд зохистой байгаагаа үзүүлэхүйц үр жимс авчраагүй аваас тэд баптисм хүртдэггүй байв.
- 2 Бас тэд харууссан зүрх болоод гэмшсэн сэтгэлтэйгээр ирж, мөн тэд бүх нүглүүдээ үнэхээр наманчилсныг сүмд гэрчлэхээс бусдаар бол тэд хэнийг ч баптисмд хүлээж авдаггүй байв.
- 3 Мөн тэд төгсгөл хүртэл түүнд үйлчлэх шийдвэртэйгээр, Христийн нэрийг өөрсдөдөө авсан тэднээс өөр хэн ч баптисмд хүлээн авагддаггүй байлаа.
- 4 Мөн тэд баптисмд хүлээн авагдсаны дараа, мөн Ариун Сүнсний хүчээр нөлөөлөгдөж мөн цэвэршигдсэний дараа, тэд Христийн сүмийн хүмүүсийн дунд тоологддог байв; мөн тэднийг зөв замд байлгахын тулд, итгэлийнх нь үүсгэгч мөн төгсгөгч нь болох Христийн сайн үйлсийн дээр л тулгуурлан тэднийг залбиралд үргэлж анхааралтай байлгахаар Бурханы сайн үгээр дурсагдан мөн тэжээгдэхийн учир тэдний нэрс тэмдэглэгддэг байв.
- 5 Мөн сүмийнхэн мацаг барихаар мөн залбирахаар, мөн өөр хоорондоо бодгалиудынхаа аз жаргалын талаар ярихаар ойр ойрхон цугладаг байв.
- 6 Мөн тэд Их Эзэн Есүсийг дурсан санаж талх, дарснаас хүртэхийн тулд цуглан ойр ойрхон цугладаг байв.
- 7 Мөн тэдний дунд ямар ч алдас байхгүйн төлөө дагаж мөрдөхдөө чанд байв; мөн алдсыг үйлдсэн нь мэдэгдсэн хэн боловч, мөн сүмийн гурван гэрч тэднийг ахлагч нарын өмнө буруушааж, мөн хэрэв тэд наманчлахгүй, мөн буруугаа тоочихгүй аваас, тэдний нэрс арилгагдаж, мөн тэд Христийн хүмүүсийн дунд тоологддоггүй байв.
- 8 Харин тэд үнэн сэтгэлээсээ наманчилж мөн өршөөлийг эрэлхийлэх болгондоо, тэд өршөөгддөг байлаа.
- 9 Мөн цуглаанууд Сүнсний нөлөөний дагуу, мөн Ариун Сүнсний хүчээр Сүмээр хөтлөгддөг байв; учир нь Ариун Сүнсний хүч тэднийг номлоход, эсвээс ухуулахад, эсвээс залбирахад, эсвээс гуйхад, эсвээс дуулахад удирддагчлан, үүнчлэн тэр нь хийгддэг байв.

## Moroni 6

And now I speak concerning baptism. Behold, elders, priests, and teachers were baptized; and they were not baptized save they brought forth fruit meet that they were worthy of it.

Neither did they receive any unto baptism save they came forth with a broken heart and a contrite spirit, and witnessed unto the church that they truly repented of all their sins.

And none were received unto baptism save they took upon them the name of Christ, having a determination to serve him to the end.

And after they had been received unto baptism, and were wrought upon and cleansed by the power of the Holy Ghost, they were numbered among the people of the church of Christ; and their names were taken, that they might be remembered and nourished by the good word of God, to keep them in the right way, to keep them continually watchful unto prayer, relying alone upon the merits of Christ, who was the author and the finisher of their faith.

And the church did meet together oft, to fast and to pray, and to speak one with another concerning the welfare of their souls.

And they did meet together oft to partake of bread and wine, in remembrance of the Lord Jesus.

And they were strict to observe that there should be no iniquity among them; and whoso was found to commit iniquity, and three witnesses of the church did condemn them before the elders, and if they repented not, and confessed not, their names were blotted out, and they were not numbered among the people of Christ.

But as oft as they repented and sought forgiveness, with real intent, they were forgiven.

And their meetings were conducted by the church after the manner of the workings of the Spirit, and by the power of the Holy Ghost; for as the power of the Holy Ghost led them whether to preach, or to exhort, or to pray, or to supplicate, or to sing, even so it was done.



## Моронай 7

- 1 Мөн эдүгээ би, Моронай, итгэл, найдвар, мөн энэрлийн талаар ярьсан өөрийн эцэг Мормоны үгсийн цөөн хэдийг бичье; учир нь шүтлэгийн газрын тулд тэдний барьсан синагогт тэрбээр тэдэнд зааж байхдаа тэрээр хүмүүст энэ маягаар ярьсан ажээ.
- 2 Мөн эдүгээ би, Мормон, хайрт ах дүү нар минь, та нарт ярья; мөн Бурхан Эцэг, мөн бидний Их Эзэн Есүс Христийн ач ивээлээр, мөн түүний ариун тааллаар, түүний надад өгсөн дуудлагын бэлгийн учир, би энэ удаа та нарт ярих нь зөвшөөрөгдсөн билээ.
- 3 Иймийн тул, би сүмийнх болох та нарт, Христийн амгалан дөлгөөн дагалдагчид болох та нарт, мөн энэ цагаас хойшид та нар тэнгэрт түүнтэй амрах болтлоо, Их Эзэний амралтыг олж чадахаар хангалттай найдвар олж авсан та нарт ярья.
- 4 Мөн эдүгээ ах дүүс минь, та нар хүмүүний үрстэй хамт амгалан дөлгөөн алхдагийн тань учир, та нарын талаар би эдгээр дүгнэлтэнд хүрэв.
- 5 Учир нь тэдний үйлүүдээр та нар тэднийг мэдэх болно хэмээсэн Бурханы тэрхүү үгийг би санаж байна; учир нь хэрэв тэдний үйлс сайн байх аваас, тэгвэл тэд ч түүнчлэн сайн бөлгөө.
- 6 Учир нь болгоогтун, хүмүүн нь хилэнцэт байваас сайн болох түүнийг үйлдэж чадахгүй гэж Бурхан хэлжээ; учир нь хэрэв тэр бэлэг өргөж, эсвээс Бурханд залбирлаа ч, тэрбээр үүнийг үнэн сэтгэлээсээ хийхгүй аваас, энэ нь түүнд ямар ч ашиггүй байх болно.
- 7 Учир нь болгоогтун, энэ нь түүний хувьд зөв шударга хэмээн тооцогдохгүй.
- 8 Учир нь болгоогтун, хэрэв хилэнцэт нэгэн бэлэг өгвөөс, тэр үүнийгээ дургүйгээр үйлддэг; иймийн тул энэ нь түүний хувьд уг бэлгийг тэр авч үлдсэнтэй нэгэн адил тооцогддог; иймийн тул тэр Бурханы өмнө хилэнцэт хэмээн тооцогдох бөлгөө.
- 9 Мөн түүнчлэн үүний нэгэн адилаар хэрэв тэр залбирахдаа зүрх сэтгэлийнхээ үнэн хүслээр бус аваас, энэ нь хүмүүнд хилэнцэт хэмээн тооцогдох ажгуу; тийм ээ, мөн энэ нь түүнд ямар ч ашиггүй, учир нь Бурхан тийм нэгийг ч хүлээн авдаггүй.

## Moroni 7

And now I, Moroni, write a few of the words of my father Mormon, which he spake concerning faith, hope, and charity; for after this manner did he speak unto the people, as he taught them in the synagogue which they had built for the place of worship.

And now I, Mormon, speak unto you, my beloved brethren; and it is by the grace of God the Father, and our Lord Jesus Christ, and his holy will, because of the gift of his calling unto me, that I am permitted to speak unto you at this time.

Wherefore, I would speak unto you that are of the church, that are the peaceable followers of Christ, and that have obtained a sufficient hope by which ye can enter into the rest of the Lord, from this time henceforth until ye shall rest with him in heaven.

And now my brethren, I judge these things of you because of your peaceable walk with the children of men.

For I remember the word of God which saith by their works ye shall know them; for if their works be good, then they are good also.

For behold, God hath said a man being evil cannot do that which is good; for if he offereth a gift, or prayeth unto God, except he shall do it with real intent it profiteth him nothing.

For behold, it is not counted unto him for righteousness.

For behold, if a man being evil giveth a gift, he doeth it grudgingly; wherefore it is counted unto him the same as if he had retained the gift; wherefore he is counted evil before God.

And likewise also is it counted evil unto a man, if he shall pray and not with real intent of heart; yea, and it profiteth him nothing, for God receiveth none such.

10 Иймийн тул, хилэнцэт болох хүмүүн нь сайн болох түүнийг хийж чадахгүй; бас тэрбээр сайн бэлэг ч өгөхгүй.

11 Учир нь болгоогтун, гашуун эх булаг сайн усыг өгч чадахгүй; бас сайн эх булаг нь гашуун усыг өгдөггүй; иймийн тул, чөтгөрийн зарц болох хүмүүн Христийг дагаж чадахгүй; мөн хэрэв тэрбээр Христийг дагавал тэр чөтгөрийн зарц байж чадахгүй.

12 Иймийн тул, сайн болох бүх зүйл Бурханаас ирдэг; мөн хилэнцэт болох тэр нь чөтгөрөөс ирдэг; учир нь чөтгөр Бурханы дайсан, мөн үргэлж түүний эсрэг тулалддаг, мөн нүгэл үйлдэхэд, мөн хилэнцэтийг үйлдэхэд үргэлж урьж мөн татдаг буюу.

13 Гэвч болгоогтун, Бурханых болох тэр нь үргэлж сайныг үйлдэхэд урьж мөн татдаг; иймийн тул, сайныг үйлдэхэд мөн Бурханыг хайрлахад, мөн түүнд үйлчлэхэд урьж мөн татдаг тэрхүү юм бүр, Бурханаар нөлөөлөгддөг.

14 Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар хилэнцэт болох тэр нь Бурханаас хэмээн, эсвээс сайн мөн Бурханаас болох тэр нь чөтгөрөөс байдаг хэмээн бодохгүй байхыг анхаарагтун.

15 Учир нь болгоогтун, ах дүүс минь, та нар сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тулд дүгнэх нь та нарт өгөгдсөн билээ; мөн та нар төгс мэдлэгээр мэдэж болохын тулд дүгнэх арга нь өдрийн гэрэл, шөнийн харанхуйн ялгаа нь илэрхий байдаг лугаа адил тодорхой байдаг.

16 Учир нь болгоогтун, Христийн Сүнс хүн бүрд тэрбээр сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тулд өгөгдсөн байдаг, иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлье; учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн сайныг хийхийг урьдаг юм болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг; иймийн тул та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно.

Wherefore, a man being evil cannot do that which is good; neither will he give a good gift.

For behold, a bitter fountain cannot bring forth good water; neither can a good fountain bring forth bitter water; wherefore, a man being a servant of the devil cannot follow Christ; and if he follow Christ he cannot be a servant of the devil.

Wherefore, all things which are good cometh of God; and that which is evil cometh of the devil; for the devil is an enemy unto God, and fighteth against him continually, and inviteth and enticeth to sin, and to do that which is evil continually.

But behold, that which is of God inviteth and enticeth to do good continually; wherefore, every thing which inviteth and enticeth to do good, and to love God, and to serve him, is inspired of God.

Wherefore, take heed, my beloved brethren, that ye do not judge that which is evil to be of God, or that which is good and of God to be of the devil.

For behold, my brethren, it is given unto you to judge, that ye may know good from evil; and the way to judge is as plain, that ye may know with a perfect knowledge, as the daylight is from the dark night.

For behold, the Spirit of Christ is given to every man, that he may know good from evil; wherefore, I show unto you the way to judge; for every thing which inviteth to do good, and to persuade to believe in Christ, is sent forth by the power and gift of Christ; wherefore ye may know with a perfect knowledge it is of God.

17 Гэвч хилэнцтийг хийхийг мөн Христэд үл итгэхийг, мөн түүнийг үгүйсгэхийг, мөн Бурханд эс үйлчлэхийг хүмүүнд ятгах юуг боловч, тэгвэл та нар энэ нь чөтгөрөөс гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно; учир нь чөтгөр энэ маягаар ажилладаг, учир нь тэрбээр, бас түүний элчүүд ч гэсэн адил; бас түүнд өөрсдийгөө харъяалуулах тэд ч гэсэн сайныг хийхийг хүмүүнд ятгадаггүй, үгүй, хэнд ч үгүй.

18 Мөн эдүгээ, ах дүүс минь, түүгээр дүгнэж болох, Христийн гэрэл болох тэрхүү гэрлийг та нар мэдэх учир, буруугаар дүгнэхгүй байхаа мэдэгтүн; учир нь та нар шүүх тэрхүү шүүлтээрээ түүнчлэн шүүгдэх болно.

19 Иймийн тул, ах дүүс минь, та нар сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тул Христийн гэрлээр шаргуу судлахыг би та нараас гуйя; мөн хэрэв та нар сайн зүйл болгоноос зууран барьж, мөн үүнийг үл буруушаах аваас, та нар гарцаагүй Христийн хүүхэд байх болно.

20 Мөн эдүгээ, ах дүүс минь, та нар сайн зүйл болгоноос барих нь явал боломжтой байх вэ

21 Мөн эдүгээ би итгэлийн тухай ярина хэмээсэн түүнийхээ тухай ярья; мөн та нар сайн юм болгоноос барьж болох замыг та нарт би хэлье.

22 Учир нь болгоогтун, үүрдээс үүрдэд оршихын учир, Бурхан бүх зүйлийг мэдэхийн учир, болгоогтун, тэрбээр хүмүүний үрсэд тохинуулуулахаар, Христийн ирэлтийн талаар; мөн Христээр сайн юм болгон ирэхийг мэдүүлэхээр тэнгэр элчүүдийг илгээсэн болой.

23 Мөн түүнчлэн, Христ ирэх болно хэмээн зарлан Бурхан өөрийн амаар бошиглогчдод тунхагласан билээ.

24 Мөн болгоогтун, тэрбээр хүмүүний үрсэд сайн болох зүйлийг тунхагласан олон янзын аргууд байсан; мөн сайн болох бүх зүйл Христээс ирдэг; өөрөөр бол хүмүүн нь унасан байсан, мөн тэдэнд ямар ч сайн зүйл ирэх аргагүй байсан билээ.

But whatsoever thing persuadeth men to do evil, and believe not in Christ, and deny him, and serve not God, then ye may know with a perfect knowledge it is of the devil; for after this manner doth the devil work, for he persuadeth no man to do good, no, not one; neither do his angels; neither do they who subject themselves unto him.

And now, my brethren, seeing that ye know the light by which ye may judge, which light is the light of Christ, see that ye do not judge wrongfully; for with that same judgment which ye judge ye shall also be judged.

Wherefore, I beseech of you, brethren, that ye should search diligently in the light of Christ that ye may know good from evil; and if ye will lay hold upon every good thing, and condemn it not, ye certainly will be a child of Christ.

And now, my brethren, how is it possible that ye can lay hold upon every good thing?

And now I come to that faith, of which I said I would speak; and I will tell you the way whereby ye may lay hold on every good thing.

For behold, God knowing all things, being from everlasting to everlasting, behold, he sent angels to minister unto the children of men, to make manifest concerning the coming of Christ; and in Christ there should come every good thing.

And God also declared unto prophets, by his own mouth, that Christ should come.

And behold, there were divers ways that he did manifest things unto the children of men, which were good; and all things which are good cometh of Christ; otherwise men were fallen, and there could no good thing come unto them.

25 Иймийн тул, тэнгэр элчүүдийн тохинууллаар, мөн Бурханы амнаас гарсан үг бүрээр, хүмүүн нь Христэд итгэх итгэлээ хөгжүүлж эхэлсэн юм; мөн тийн тэд итгэлээр, сайн юм болгоноос зууран барив; мөн энэ нь Христийн ирэлт хүртэл тийн байсан болой.

26 Мөн түүнийг ирсний дараа хүмүүн түүнчлэн түүний нэрэнд итгэх итгэлээр аврагдсан юм; мөн итгэлээр, тэд Бурханы хөвгүүд болно. Мөн Христ амьд нь гарцаагүйн адил тэрбээр эдгээр үгийг бидний эцэг өвгөдөд ярьсан, үүнд хэлрүүн: Та нар хүлээж авах болно хэмээн итгэх итгэлтэйгээр, миний нэрээр Эцэгээс гуйх, сайн болох юм юу боловч, болгоогтун энэ нь та нарт хийгдэх болно.

27 Иймийн тул, хайрт ах дүүс минь, Христ тэнгэр өөд дээшлэн одсон, мөн хүмүүний үрсийн дээрх өөрийн нигүүлслийн эрхийг Эцэгээсээ шаардахаар Бурханы баруун мутар талд суулаа гээд гайхамшгууд байхаа больсон гэж үү

28 Учир нь тэрбээр хуулийн шаардлагуудыг хангасан, мөн тэрбээр өөрт итгэлтэй тэд бүгдийг шаарддаг; мөн түүнд итгэлтэй тэд сайн зүйл болгоноос зууран барьдаг; иймийн тул тэрбээр хүмүүний үрсийн хэргийг өмгөөлдөг; мөн тэрбээр мөнхөд тэнгэрт оршдог.

29 Мөн тэрбээр үүнийг хийлээ гээд, хайрт ах дүүс минь, гайхамшгууд байхаа больсон гэж үү? Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; бас тэнгэр элчүүд ч хүмүүний үрсэд тохинуулахаа больсон нь үгүй.

30 Учир нь болгоогтун, хүчит итгэлтэй мөн гуйвшгүй бодолтой тэдэнд бурханлиг чанар бүрээр өөрсдийгөө үзүүлэхээр, түүний зарлигийн үгийн дагуу тохинуулахаар тэд түүнд харьяалагддаг.

31 Мөн хүмүүнийг наманчлалд дуудах нь, мөн хүмүүний үрстэй түүний хийсэн, Эцэгийн гэрээнүүдийн ажлыг хийж мөн гүйцэлдүүлэх нь, тэд нь түүний тухай гэрчлэлийг хуваалцаж болохын тулд Христийн үгийг Их Эзэний сонгогдсон савнуудад тунхагласнаар хүмүүний үрсийн дундах замыг бэлтгэх нь тэдний тохинууллын алба юм.

Wherefore, by the ministering of angels, and by every word which proceeded forth out of the mouth of God, men began to exercise faith in Christ; and thus by faith, they did lay hold upon every good thing; and thus it was until the coming of Christ.

And after that he came men also were saved by faith in his name; and by faith, they become the sons of God. And as surely as Christ liveth he spake these words unto our fathers, saying: Whatsoever thing ye shall ask the Father in my name, which is good, in faith believing that ye shall receive, behold, it shall be done unto you.

Wherefore, my beloved brethren, have miracles ceased because Christ hath ascended into heaven, and hath sat down on the right hand of God, to claim of the Father his rights of mercy which he hath upon the children of men?

For he hath answered the ends of the law, and he claimeth all those who have faith in him; and they who have faith in him will cleave unto every good thing; wherefore he advocateth the cause of the children of men; and he dwelleth eternally in the heavens.

And because he hath done this, my beloved brethren, have miracles ceased? Behold I say unto you, Nay; neither have angels ceased to minister unto the children of men.

For behold, they are subject unto him, to minister according to the word of his command, showing themselves unto them of strong faith and a firm mind in every form of godliness.

And the office of their ministry is to call men unto repentance, and to fulfil and to do the work of the covenants of the Father, which he hath made unto the children of men, to prepare the way among the children of men, by declaring the word of Christ unto the chosen vessels of the Lord, that they may bear testimony of him.

32 Мөн ийн хийснээр, үлдсэн бусад хүмүүс Ариун Сүнсний хүчнийхээ дагуу тэдний зүрх сэтгэлд байр олж болох Христэд итгэлтэй байж болох замыг Их Эзэн Бурхан бэлтгэдэг; мөн энэ маягаар Эцэг, хүмүүний үрстэй хийсэн өөрийн гэрээнүүдийг улируулан тохиолгодог.

33 Мөн Христ хэлдэг: Хэрэв та нар надад итгэлтэй байх аваас та нар миний хувьд шаардлагатай болох аливаа зүйлийг хийх хүчтэй байх болно.

34 Мөн тэрбээр: Газар дэлхийн хязгаарууд та нар бүгд аврагдаж болохын тулд наманчлагтун, мөн надад ирж, мөн миний нэрээр баптисм хүртэгтүн, мөн та нар надад итгэлтэй байгтун хэмээн хэлдэг.

35 Мөн эдүгээ, хайрт ах дүүс минь, хэрэв та нарт миний ярьсан эдгээр зүйлс үнэн байх аваас, мөн тэдгээр нь үнэнийг Бурхан эцсийн өдөр хүчтэйгээр мөн агуу алдар суугаар та нарт үзүүлэх болно, мөн хэрэв тэдгээр нь үнэн байхад гайхамшгуудын өдөр байхаа больсон гэж үү

36 Эсвээс тэнгэр элчүүд хүмүүний үрсэд үзэгдэхээ больсон гэж үү? Эсвээс тэрбээр Ариун Сүнсний хүчийг тэднээс далдалсан гэж үү? Эсвээс тэр, цаг хугацаа үргэлжлэн байхад, эсвээс газар дэлхий оршсоор байхад, эсвээс үүний гадаргуу дээр аврагдаж болох ганцхан боловч хүн байхад тэгэх гэж үү

37 Болгоогтун би та нарт хэлнэ, Үгүй; учир нь гайхамшгууд үйлдэгдэх нь итгэлээр бөлгөө; мөн хүмүүнд тэнгэр элчүүд үзэгдэж мөн тохинуулах нь итгэлээр юм; иймийн тул, хэрэв эдгээр зүйл байхаа больсон бол хүмүүний үрсэд халаг болог, учир нь энэ бол итгэлгүйн учир, тиймийн тул бүгд хоосон юм.

38 Учир нь Христийн үгсийн дагуу түүний нэрэнд итгэлтэй байхгүй бол ямар ч хүн аврагдаж чадахгүй; иймийн тул, хэрэв эдгээр зүйлс байхаа больсон гэвэл, тэгвэл итгэл ч түүнчлэн үгүй болсон гэсэн үг; мөн хүмүүний байдал аймшигтай байна, учир нь тэд гэтэлгэл хийгдээгүй мэт байх болно.

And by so doing, the Lord God prepareth the way that the residue of men may have faith in Christ, that the Holy Ghost may have place in their hearts, according to the power thereof; and after this manner bringeth to pass the Father, the covenants which he hath made unto the children of men.

And Christ hath said: If ye will have faith in me ye shall have power to do whatsoever thing is expedient in me.

And he hath said: Repent all ye ends of the earth, and come unto me, and be baptized in my name, and have faith in me, that ye may be saved.

And now, my beloved brethren, if this be the case that these things are true which I have spoken unto you, and God will show unto you, with power and great glory at the last day, that they are true, and if they are true has the day of miracles ceased?

Or have angels ceased to appear unto the children of men? Or has he withheld the power of the Holy Ghost from them? Or will he, so long as time shall last, or the earth shall stand, or there shall be one man upon the face thereof to be saved?

Behold I say unto you, Nay; for it is by faith that miracles are wrought; and it is by faith that angels appear and minister unto men; wherefore, if these things have ceased wo be unto the children of men, for it is because of unbelief, and all is vain.

For no man can be saved, according to the words of Christ, save they shall have faith in his name; wherefore, if these things have ceased, then has faith ceased also; and awful is the state of man, for they are as though there had been no redemption made.

39 Гэвч болгоогтун, хайрт ах дүүс минь, би та нарын талаар илүү сайн дүгнэлтэд хүрэв, учир нь хүлцэнгүй номхон байдлын тань учир Христэд итгэх итгэл та нарт байгаа хэмээх дүгнэлтэнд би хүрэв; учир нь хэрэв та нар түүнд итгэлгүй байвал, тэгвэл та нар түүний сүмийн хүмүүсийн дунд тоологдох нь тохиромжгүй билээ.

40 Мөн тэрчлэн, хайрт ах дүүс минь, би та нарт найдварын талаар ярьмаар байна. Та нар найдваргүйгээр, яахан итгэлийг олж чадах билээ

41 Мөн та нар юуны төлөө найдах билээ? Болгоогтун та нар Христийн цагаатгал, мөн түүний амилалтын хүчээр, мөнх амьдралд босгогдохын тулд найдахыг би та нарт хэлье, мөн энэ нь амлалтын дагуу түүнд итгэлтэйн тань учир болой.

42 Иймийн тул, хүмүүн итгэлтэй аваас түүнд найдвар байх нь гарцаагүй; учир нь итгэлгүйгээр ямар ч найдвар байж чадахгүй.

43 Мөн тэрчлэн, болгоогтун тэр хүлцэнгүй даруу, мөн зүрх сэтгэлдээ номхон байхгүй аваас, түүнд итгэл хийгээд найдвар байх аргагүйг би та нарт хэлнэ.

44 Хэрэв тийм аваас, түүний итгэл хийгээд найдвар нь хоосон, учир нь хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон байхаас бусдаар, хэн ч Бурханы өмнө хүлээн зөвшөөрөгдөхүйц байхгүй; мөн хэрэв хүмүүн хүлцэнгүй даруу мөн зүрх сэтгэлдээ номхон, мөн Ариун Сүнсний хүчээр Есүс бол Христ гэдгийг хүлээн зөвшөөрдөг аваас, түүнд энэрэл байх нь гарцаагүй; учир нь түүнд энэрэл үгүй бол тэр хэн ч биш билээ; иймийн тул түүнд энэрэл байх нь гарцаагүй.

45 Мөн энэрэл бол удаан тэсвэрлэдэг, мөн сайхан сэтгэлтэй, мөн атаархаж жөтөөрхөх нь үгүй, мөн онгирч хөөрдөггүй, өөрийнхийгөө эрэлхийлдэггүй, амар өдөөн хатгагддаггүй, ямар ч хилэнцтийг боддоггүй, мөн алдаст баясах нь үгүй, харин үнэнд баясдаг, бүх зүйлийг хүлцдэг, бүх зүйлд итгэдэг, бүх зүйлд найддаг, бүх зүйлийг тэвчдэг.

46 Иймийн тул, хайрт ах дүүс минь, хэрэв та нарт энэрэл үгүй бол, та нар хэн ч биш, учир нь энэрэл хэзээ ч дуусдаггүй; иймийн тул, бүхнээс илүү агуу тэрхүү энэрлээс зууран барь, учир нь бүх зүйл дуусах ёстой—

But behold, my beloved brethren, I judge better things of you, for I judge that ye have faith in Christ because of your meekness; for if ye have not faith in him then ye are not fit to be numbered among the people of his church.

And again, my beloved brethren, I would speak unto you concerning hope. How is it that ye can attain unto faith, save ye shall have hope?

And what is it that ye shall hope for? Behold I say unto you that ye shall have hope through the atonement of Christ and the power of his resurrection, to be raised unto life eternal, and this because of your faith in him according to the promise.

Wherefore, if a man have faith he must needs have hope; for without faith there cannot be any hope.

And again, behold I say unto you that he cannot have faith and hope, save he shall be meek, and lowly of heart.

If so, his faith and hope is vain, for none is acceptable before God, save the meek and lowly in heart; and if a man be meek and lowly in heart, and confesses by the power of the Holy Ghost that Jesus is the Christ, he must needs have charity; for if he have not charity he is nothing; wherefore he must needs have charity.

And charity suffereth long, and is kind, and envieth not, and is not puffed up, seeketh not her own, is not easily provoked, thinketh no evil, and rejoiceth not in iniquity but rejoiceth in the truth, beareth all things, believeth all things, hopeth all things, endureth all things.

Wherefore, my beloved brethren, if ye have not charity, ye are nothing, for charity never faileth. Wherefore, cleave unto charity, which is the greatest of all, for all things must fail—

47 Гэвч энэрэл бол Христийн цэвэр хайр, мөн энэ нь үүрд үл цөхрөх ажгуу; мөн эцсийн өдөр үүнийг эзэмшиж байгаа хэнд боловч, түүнд сайн байх болно.

48 Иймийн тул, хайрт ах дүүс минь, та нар түүний Хүү, Есүс Христийн үнэн дагалдагчид бүгдийн дээр түүний цутгасан хайраар дүүргэгдэж болохын төлөө; та нар Бурханы хөвгүүд болж болохын тулд; тэрбээр хүрч ирэхэд бид түүнтэй адил байх болно, учир нь бид түүнийг байгаагаар нь харах болно гэсний учир, бидэнд энэ найдвар байж болохын тулд, түүний цэврийн адил бид цэвэр болгогдож болохын тулд зүрхнийхээ бүхий л эрч хүчээр Эцэгт хандан залбирагтун. Амен.

But charity is the pure love of Christ, and it endureth forever; and whoso is found possessed of it at the last day, it shall be well with him.

Wherefore, my beloved brethren, pray unto the Father with all the energy of heart, that ye may be filled with this love, which he hath bestowed upon all who are true followers of his Son, Jesus Christ; that ye may become the sons of God; that when he shall appear we shall be like him, for we shall see him as he is; that we may have this hope; that we may be purified even as he is pure. Amen.

## Моронай 8

- 1 Миний эцэг Мормоны, Моронай надад бичиглэсэн захидал оршвой; мөн энэ нь намайг тохинуулалд дуудагдсанаас хойш удалгүй надад бичигдсэн юм. Мөн ийм байдлаар тэрээр надад бичсэн билээ, өгүүлсэн нь:
- 2 Моронай, хайрт хүү минь, Их Эзэн Есүс Христ чамд анхааран хандсан билээ, мөн өөрийн тохинуулалд, мөн ариун ажилдаа чамайг дуудсанд би үлэмж баяснам.
- 3 Тэрбээр өөрийн хэмжээлшгүй сайн сайхан мөн ач ивээлээр өөрийнх нь нэрэнд итгэх итгэлийн эцсийг хүртэлх тэвчээрээр чамайг хадгалаасай хэмээн, Бурхан Эцэгт түүний Ариун Хүүхэд, Есүсийн нэрээр би үргэлж залбиран, чамайг залбиралдаа үргэлж анхаардаг билээ.
- 4 Мөн эдүгээ, миний хүү, намайг үлэмж гонсойлгож буй түүний талаар би чамд ярья; учир нь та нарын дунд арцалдаанууд гардаг нь намайг гонсойлгож байна.
- 5 Учир нь, хэрэв би үнэнийг мэдсэн аваас, бага насны хүүхдүүдийн тань баптисмын талаар та нарын дунд арцалдаан байгаа юм.
- 6 Мөн эдүгээ, хүү минь, та нарын дундаас энэхүү ноцтой алдаа зайлуулагдахын тулд, чамайг хичээнгүйлэн хөдөлмөрлөөсэй хэмээн хүснэ би; учир нь, энэхүү зорилгын улмаас би энэ захидлыг бичиж байна.
- 7 Учир нь та нарын талаар эдгээр зүйлсийг би мэдэнгүүтээ л энэ хэргийн талаар Их Эзэнээс лавлалаа. Мөн Ариун Сүнсний хүчээр Их Эзэний үг надад ирж, хэлсэн нь:
- 8 Өөрийн гэтэлгэгч, өөрийн Их Эзэн, мөн өөрийн Бурхан Христийн үгсийг сонс. Болгоогтун, би дэлхийд зөв шударгыг үйлдэгчдийг бус, нүгэлтнүүдийг наманчлалд дуудахаар ирсэн билээ; эрүүлд эмчийн хэрэгцээ үгүй, харин өвчтэй тэдэнд; иймийн тул, бага насны хүүхдүүд эрүүл, учир нь тэд нүгэл үйлдэх чадваргүй юм; иймийн тул Адамын зүхэл, тэр нь тэдний дээр хүчгүй байхаар, тэднээс надаар зайлуулагдсан болой; мөн хөвч хөндөх хууль надаар эцэс болсон юм.

## Moroni 8

An epistle of my father Mormon, written to me, Moroni; and it was written unto me soon after my calling to the ministry. And on this wise did he write unto me, saying:

My beloved son, Moroni, I rejoice exceedingly that your Lord Jesus Christ hath been mindful of you, and hath called you to his ministry, and to his holy work.

I am mindful of you always in my prayers, continually praying unto God the Father in the name of his Holy Child, Jesus, that he, through his infinite goodness and grace, will keep you through the endurance of faith on his name to the end.

And now, my son, I speak unto you concerning that which grieveth me exceedingly; for it grieveth me that there should disputations rise among you.

For, if I have learned the truth, there have been disputations among you concerning the baptism of your little children.

And now, my son, I desire that ye should labor diligently, that this gross error should be removed from among you; for, for this intent I have written this epistle.

For immediately after I had learned these things of you I inquired of the Lord concerning the matter. And the word of the Lord came to me by the power of the Holy Ghost, saying:

Listen to the words of Christ, your Redeemer, your Lord and your God. Behold, I came into the world not to call the righteous but sinners to repentance; the whole need no physician, but they that are sick; wherefore, little children are whole, for they are not capable of committing sin; wherefore the curse of Adam is taken from them in me, that it hath no power over them; and the law of circumcision is done away in me.



- 9 Мөн энэ байдлаар Бурханы үгийг Ариун Сүнс надад мэдүүлсэн буюу; иймийн тул, хайрт хүү минь, та нар бага насны хүүхдүүдэд баптисм хүртээх нь Бурханы өмнөх сүрхий элэглэл болохыг би мэднэ.
- 10 Болгоогтун энэ зүйлийг та нар заах болно гэдгийг би чамд хэлье—хариуцлага хүлээх мөн нүгэл үйлдэх чадвартай тэдэнд наманчлал мөн баптисмыг; тийм ээ, тэд наманчилж мөн баптисм хүртэн, мөн бага насны хүүхдүүдийнхээ адил өөрсдийгөө даруухан болгох ёстой, тэгвэл тэд бүгдээр бага насны хүүхдүүдийнхээ хамт аврагдах болно гэдгийг эцэг эхчүүдэд заагтун.
- 11 Мөн тэдний бага насны хүүхдүүдэд наманчлал ч, бас баптисм ч огт хэрэггүй болой. Болгоогтун, нүглийн ангижралыг авах зарлигуудыг биелүүлэхийн тулд баптисм нь наманчлалд хүргэдэг.
- 12 Гэвч бага насны хүүхдүүд бүр дэлхийн үүслээс Христээр амьд; хэрэв тийм бус аваас, Бурхан нь ялгаварладаг Бурхан, мөн түүнчлэн хувирамтгай Бурхан, мөн нүүр тал харагч болно; учир нь хичнээн олон бага насны хүүхдүүд баптисмгүйгээр нас нөгчсөн билээ!
- 13 Иймийн тул, хэрэв бага насны хүүхдүүд баптисмгүйгээр аврагдаж чадахгүй аваас, тэд эцэсгүй тамд одсон байх нь гарцаагүй.
- 14 Болгоогтун би та нарт хэлнэ, бага насны хүүхдүүдэд баптисм хэрэгтэй хэмээн боддог тэр нь гашуудлын гүнд мөн алдсын хүлээст байгаа буюу; учир нь түүнд итгэл, найдвар, мөн энэрэл ч үгүй болой; иймийн тул, тэрбээр уг бодолдоо өнгөрвөөс, тэрбээр там уруу явах нь гарцаагүй болой.
- 15 Учир нь Бурхан баптисмаар нэг хүүхдийг аврахад, мөн нөгөө нь баптисмгүйн тулд эрсдэх ёстой хэмээн бодохын ёс бус нь аймшигтай юм.
- 16 Энэ байдлаар Их Эзэний замуудыг гажуудуулдаг тэдэнд халаг, учир нь тэд наманчлахгүй аваас тэд мөхөх болно. Болгоогтун, би Бурханы эрх мэдэлтэй учир зоригтойгоор ярьж байна; мөн би хүмүүний юу хийж чадахаас үл айна; учир нь төгс хайр бүх айдсыг зайлуулдаг.

And after this manner did the Holy Ghost manifest the word of God unto me; wherefore, my beloved son, I know that it is solemn mockery before God, that ye should baptize little children.

Behold I say unto you that this thing shall ye teach—repentance and baptism unto those who are accountable and capable of committing sin; yea, teach parents that they must repent and be baptized, and humble themselves as their little children, and they shall all be saved with their little children.

And their little children need no repentance, neither baptism. Behold, baptism is unto repentance to the fulfilling the commandments unto the remission of sins.

But little children are alive in Christ, even from the foundation of the world; if not so, God is a partial God, and also a changeable God, and a respecter to persons; for how many little children have died without baptism!

Wherefore, if little children could not be saved without baptism, these must have gone to an endless hell.

Behold I say unto you, that he that supposeth that little children need baptism is in the gall of bitterness and in the bonds of iniquity; for he hath neither faith, hope, nor charity; wherefore, should he be cut off while in the thought, he must go down to hell.

For awful is the wickedness to suppose that God saveth one child because of baptism, and the other must perish because he hath no baptism.

Wo be unto them that shall pervert the ways of the Lord after this manner, for they shall perish except they repent. Behold, I speak with boldness, having authority from God; and I fear not what man can do; for perfect love casteth out all fear.

17 Мөн би үүрдийн хайр болох энэрлээр дүүргэгдсэн; иймийн тул, бүх хүүхдүүд миний хувьд адил юм; иймийн тул, би бага насны хүүхдүүдийг төгс хайраар хайрладаг; мөн тэд бүгдээр адилхан мөн авралыг хүртэгсэд бөлгөө.

18 Учир нь Бурхан бол ялгаварлагч Бурхан биш, мөн өөрчлөгдөгч нэгэн бишийг; харин тэрбээр бүх үүрд мөнхөөс бүх үүрд мөнхөд өөрчлөгдөшгүйг би мэднэ.

19 Бага насны хүүхдүүд наманчилж чадахгүй; иймийн тул, тэдэнд Бурханы хандуулсан цэвэр ариун нигүүлслийг үгүйсгэх нь аймшигт ёс бус явдал мөн, учир нь түүний нигүүлслийн улмаас тэд бүгд түүгээр амьд юм.

20 Мөн бага насны хүүхдүүдэд баптисм хэрэгтэй хэмээн хэлэх тэр нь Христийн нигүүлслийг үгүйсгэж, мөн түүний цагаатгал хийгээд түүний гэтэлгэлийн хүчийг юу ч бус хэмээн үнэлж буй хэрэг.

21 Тэдэнд халаг, учир нь тэд тамын, үхлийн, мөн төгсгөлгүй тарчлалын аюулд байна. Би үүнийг зоригтойгоор хэлнэ; Бурхан надад зарлиг болгосон юм. Тэднийг сонс мөн анхаарал тавь, эсвээс тэд Христийн шүүлтийн суудлын дэргэд та нарын эсрэг зогсох болно.

22 Учир нь болгоогтун бүх бага насны хүүхдүүд, мөн түүнчлэн хуульгүй орших тэд бүгд Христээр амьд юм. Учир нь гэтэлгэлийн хүч хуульгүй тэд бүгдэд ирдэг; иймийн тул, буруутгагдаагүй тэр нь, өөрөөр хэлбэл буруутгал дор эс орших тэр нь, наманчилж чадахгүй; мөн тийм нэгэнд баптисм ямар ч тусгүй юм—

23 Гэвч Христийн нигүүлслийг, мөн Ариун Сүнсний хүчийг үгүйсгэж, мөн үхмэл үйлд итгэлээ тавих нь Бурханы өмнөх элэглэл юм.

24 Болгоогтун, хүү минь, энэ зүйл байх учиргүй; учир нь наманчлал нь буруутгал дор буй мөн зөрчигдсөн хуулийн зүхэл дор буй тэдний төлөө юм.

25 Мөн наманчлалын анхны үр жимс бол баптисм юм; мөн итгэлээр ирдэг баптисм зарлигуудыг биелүүлэхэд хүргэдэг; мөн зарлигуудыг биелүүлэх нь нүглийн ангижралыг авчирдаг;

And I am filled with charity, which is everlasting love; wherefore, all children are alike unto me; wherefore, I love little children with a perfect love; and they are all alike and partakers of salvation.

For I know that God is not a partial God, neither a changeable being; but he is unchangeable from all eternity to all eternity.

Little children cannot repent; wherefore, it is awful wickedness to deny the pure mercies of God unto them, for they are all alive in him because of his mercy.

And he that saith that little children need baptism denieth the mercies of Christ, and setteth at naught the atonement of him and the power of his redemption.

Wo unto such, for they are in danger of death, hell, and an endless torment. I speak it boldly; God hath commanded me. Listen unto them and give heed, or they stand against you at the judgment-seat of Christ.

For behold that all little children are alive in Christ, and also all they that are without the law. For the power of redemption cometh on all them that have no law; wherefore, he that is not condemned, or he that is under no condemnation, cannot repent; and unto such baptism availeth nothing—

But it is mockery before God, denying the mercies of Christ, and the power of his Holy Spirit, and putting trust in dead works.

Behold, my son, this thing ought not to be; for repentance is unto them that are under condemnation and under the curse of a broken law.

And the first fruits of repentance is baptism; and baptism cometh by faith unto the fulfilling the commandments; and the fulfilling the commandments bringeth remission of sins;

26 Мөн нүглийн ангижрал нь даруу байдал мөн зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанарыг авчирдаг; мөн даруу байдал хийгээд зүрх сэтгэлийн хүлцэнгүй чанарын улмаас, найдвар хийгээд төгс хайраар дүүргэх Тайтгаруулагч болох Ариун Сүнсний айлчлал нь ирдэг, залбирал дахь хичээл зүтгэлийн учир бүх гэгээнтнүүд Бурхантай хамт орших эцсийг ирэх хүртэл тэрхүү хайр үл цөхрөх болно.

27 Болгоогтун, хүү минь, хэрэв ойрын үед би леменчүүдийн эсрэг явахгүй бол, би чамд дахин бичих болно. Болгоогтун, энэ үндэстний, өөрөөр хэлбэл нифайчуудын хүмүүсийн бардамнал, тэд наманчлахгүй аваас тэднийг устгалд хүргэсээр байна.

28 Тэдэнд наманчлал ирээсэй хэмээн, тэдний төлөө залбир, хүү минь. Гэвч болгоогтун, Сүнс тэдний төлөө зүтгэхээ больсон болов уу хэмээн айна би; мөн уг нутгийн энэ хэсэгт тэд түүнчлэн Бурханаас ирэх бүх хүч хийгээд эрх мэдлийг түлхэн унагахаар эрэлхийлж байна; мөн тэд Ариун Сүнсийг үгүйсгэж байна.

29 Мөн ийм агуу нэгэн мэдлэгийг эсэргүүцсэний дараа, хүү минь, бошиглогчдоор хэлэгдсэн бошиглолыг, мөн түүнчлэн бидний Аврагчийн өөрийнх нь үгсийг гүйцэлдүүлэхийн тулд тэд удахгүй мөхөх эсэнтэй.

30 Сайныг ерөөе, хүү минь, би чамд дахин бичих хүртэл, эсвээс чамтай дахин уулзах хүртэл. Амен.

And the remission of sins bringeth meekness, and lowliness of heart; and because of meekness and lowliness of heart cometh the visitation of the Holy Ghost, which Comforter filleth with hope and perfect love, which love endureth by diligence unto prayer, until the end shall come, when all the saints shall dwell with God.

Behold, my son, I will write unto you again if I go not out soon against the Lamanites. Behold, the pride of this nation, or the people of the Nephites, hath proven their destruction except they should repent.

Pray for them, my son, that repentance may come unto them. But behold, I fear lest the Spirit hath ceased striving with them; and in this part of the land they are also seeking to put down all power and authority which cometh from God; and they are denying the Holy Ghost.

And after rejecting so great a knowledge, my son, they must perish soon, unto the fulfilling of the prophecies which were spoken by the prophets, as well as the words of our Savior himself.

Farewell, my son, until I shall write unto you, or shall meet you again. Amen.

*Хүү Моронайдаа илгээсэн Мормоны хоёр дахь захидал оршвой.*

## Моронай 9

- 1 Хайрт хүү минь, би амьд хэвээр гэдгийг чи мэдэж болохын тулд би чамд дахин бичиж байна; гэвч би эмгэнэлт болох тэрний талаар заримыг бичье.
- 2 Учир нь болгоогтун, бид ялж чадаагүй тэрхүү, ширүүн тулалдаанд би леменчүүдтэй орсон; мөн Аркаинтас, мөн түүнчлэн Лурам мөн Эмрон илдээр унагаадсан болой; тийм ээ, мөн бид сонгомол эрсээсээ агуу олон тоотойг алдсандаа.
- 3 Мөн эдүгээ болгоогтун, хүү минь, леменчүүд энэ хүмүүсийг устгах вий хэмээн айна би; учир нь тэд нанманчилдаггүй, мөн Сатан тэднийг үргэлж нэг нэгэнтэй нь уур хилэнд өдөөн хатгадаг.
- 4 Болгоогтун, би тэдэнтэй үргэлж хөдөлмөрлөж байна; мөн би Бурханы үгийг хурцаар хэлэхэд тэд дагжин мөн миний эсрэг хилэгнэдэг; мөн би хурцаар эс ярихад тэд түүний эсрэг зүрх сэтгэлээ хатууруулдаг; иймийн тул, Их Эзэний Сүнс тэдний төлөө зүтгэхээ больсон болов уу хэмээн айна би.
- 5 Учир нь тэд үхлээс үл эмээх мэт надад санагдахаар тэд тийн үлэмж ихээр хилэгнэдэг; мөн тэд нэг нэгэндээ хандах хайраа гээсэн байна; мөн тэд цусанд мөн өшөө авахад үргэлжлэн шунадаг.
- 6 Мөн эдүгээ, хайрт хүү минь, тэд хатуурсан гэлээ ч, хичээнгүйгээр хөдөлмөрлөцгөөе; учир нь хэрэв бид хөдөлмөрлөхөө боливол, бид буруушаалтын дор аваачигдах болно; учир нь бид бүх зөв шударгын дайсныг ялж, мөн өөрсдийн бодгалийг Бурханы хаант улсад амрааж болохын тулд энэ махбодийн асарт байхдаа гүйцэтгэх хөдөлмөр бидэнд байна.
- 7 Мөн эдүгээ би энэ хүмүүсийн зовлон зүдгүүрийн талаар заримыг бичье. Учир нь Амороноос хүлээн авсан миний мэдлэгийн дагуу, болгоогтун, тэд Шеризагийн цамхагаас авсан олон хоригдол леменчүүдэд бий; мөн эрчүүд, эмэгтэйчүүд, мөн хүүхдүүд ч бий.

*The second epistle of Mormon to his son Moroni.*

## Moroni 9

My beloved son, I write unto you again that ye may know that I am yet alive; but I write somewhat of that which is grievous.

For behold, I have had a sore battle with the Lamanites, in which we did not conquer; and Archeantus has fallen by the sword, and also Luram and Emron; yea, and we have lost a great number of our choice men.

And now behold, my son, I fear lest the Lamanites shall destroy this people; for they do not repent, and Satan stirreth them up continually to anger one with another.

Behold, I am laboring with them continually; and when I speak the word of God with sharpness they tremble and anger against me; and when I use no sharpness they harden their hearts against it; wherefore, I fear lest the Spirit of the Lord hath ceased striving with them.

For so exceedingly do they anger that it seemeth me that they have no fear of death; and they have lost their love, one towards another; and they thirst after blood and revenge continually.

And now, my beloved son, notwithstanding their hardness, let us labor diligently; for if we should cease to labor, we should be brought under condemnation; for we have a labor to perform whilst in this tabernacle of clay, that we may conquer the enemy of all righteousness, and rest our souls in the kingdom of God.

And now I write somewhat concerning the sufferings of this people. For according to the knowledge which I have received from Amoron, behold, the Lamanites have many prisoners, which they took from the tower of Sherrizah; and there were men, women, and children.

8 Мөн тэдгээр эмэгтэйчүүдийн нөхрүүд мөн хүүхдүүдийн эцгийг нь тэд хөнөөсөн; мөн тэд эмэгтэйчүүдийг өөрсдийнх нь нөхрүүдийн цогцсоор, мөн хүүхдүүдийг өөрсдийнх нь эцгүүдийн цогцсоор тэжээдэг; мөн багыг эс тооцвол, тэд тэдэнд ус өгдөггүй.

9 Мөн леменчүүдийн энэхүү агуу жигшүүрт хэрэг байгаа хэдий ч, энэ нь Мориантум дахь бидний хүмүүсийнхээс давж гараагүй юм. Учир нь болгоогтун, леменчүүдийн охидын олныг тэд олзлон авсан бөлгөө; мөн бүхнээс илүү хамгийн эрхэм мөн үнэтэй, ариун явдал хийгээд онгон байдлаас нь тэднийг салгасны дараа—

10 Мөн тэд энэ зүйлийг хийсний дараа, тэд биеийг нь бүр үхэлд хүртэл нь тамлан, хамгийн хэрцгий балмадаар хөнөөсөн билээ; мөн тэд үүнийг хийснийхээ дараа, зүрх сэтгэлийнхээ хатуугийн улмаас, тэд цогцсыг нь зэрлэг араатнууд лугаа адил цөлмөн идсэн гээч; мөн тэд үүнийг эр зоригийн тэмдэг болгон хийсэн аж.

11 Ай хайрт хүү минь, иргэншилгүй ийм хүмүүс хэрхэн—

12 (Мөн тэд соёлтой мөн бахдам сайхан хүмүүс байсан үеэс зөвхөн цөөн хэдэн жил улирч одсон буюу)

13 Гэвч Ай хүү минь, баясал нь ийм нэтэд их жигшүүрт хэрэгт байдаг ийм хүмүүс хэрхэн—

14 Бурхан бидний эсрэг шүүлтэнд өөрийн мутрыг үл хөдөлгөнө хэмээн бид хэрхэн бодож чадах билээ

15 Болгоогтун, зүрх сэтгэл минь дуу алднам: Энэ хүмүүст халаг. Шүүлтэнд гарч ирээч, Ай Бурхан минь, мөн тэдний нүглүүдийг, мөн ёс бусыг, мөн жигшүүрт хэргүүдийг нүүрнээсээ далдлаач!

16 Мөн түүнчлэн, хүү минь, Шеризад үлдсэн олон бэлэвсэн эмэгтэйчүүд мөн тэдний охид буй; мөн леменчүүдийн авч одоогүй хоол хүнсний тэр хэсгийг, болгоогтун, Зенефайн их цэрэг авч одсон бөлгөө, мөн хүнсний тулд боломжтой газруудаар тэнүүчлүүлэхээр тэднийг орхисон ажээ; мөн настай олон эмэгтэйчүүд замдаа сульдэн мөн үхэж байна.

17 Мөн надтай буй их цэрэг сул дорой; мөн леменчүүдийн их цэрэг Шериза болон миний дунд буй; мөн Аароны их цэрэгт зугтан очсон болгон, тэд тэдний аймшигт харгислалын золиос болон унасан билээ.

And the husbands and fathers of those women and children they have slain; and they feed the women upon the flesh of their husbands, and the children upon the flesh of their fathers; and no water, save a little, do they give unto them.

And notwithstanding this great abomination of the Lamanites, it doth not exceed that of our people in Moriantum. For behold, many of the daughters of the Lamanites have they taken prisoners; and after depriving them of that which was most dear and precious above all things, which is chastity and virtue—

And after they had done this thing, they did murder them in a most cruel manner, torturing their bodies even unto death; and after they have done this, they devour their flesh like unto wild beasts, because of the hardness of their hearts; and they do it for a token of bravery.

O my beloved son, how can a people like this, that are without civilization—

(And only a few years have passed away, and they were a civil and a delightsome people)

But O my son, how can a people like this, whose delight is in so much abomination—

How can we expect that God will stay his hand in judgment against us?

Behold, my heart cries: Wo unto this people. Come out in judgment, O God, and hide their sins, and wickedness, and abominations from before thy face!

And again, my son, there are many widows and their daughters who remain in Sherrizah; and that part of the provisions which the Lamanites did not carry away, behold, the army of Zenephi has carried away, and left them to wander whithersoever they can for food; and many old women do faint by the way and die.

And the army which is with me is weak; and the armies of the Lamanites are betwixt Sherrizah and me; and as many as have fled to the army of Aaron have fallen victims to their awful brutality.

18 Ай миний хүмүүсийн завхрал! Тэдэнд эмх цэгц хийгээд нигүүлсэл гэж үгүй болжээ. Болгоогтун, би энгийн хүмүүн, мөн би энгийн хүмүүний хүч тэнхээтэй, мөн би өөрийн зарлигуудыг цаашид тулгаж чадахгүй.

19 Мөн тэд тэрс байдалдаа хүчирхэг болж; мөн тэд залуу хөгшин хэнийг ч үл хэлтрүүлэгч харгис хэрцгий болжээ; мөн тэд сайн болох тэрнээс өөр бусад бүх зүйлд баясдаг; мөн энэ нутгийн бүх гадаргуу дээрх бидний эмэгтэйчүүд мөн хүүхдүүдийн зовлон юунаас ч давж гарна; тийм ээ, хэл үүнийг хэлж үл чадна, мөн энэ нь бичигдэж эс чадна.

20 Мөн эдүгээ, хүү минь, энэ аймшигт дүр зургийг би үргэлжлүүлэн бичиж чадашгүй нь. Болгоогтун, энэ хүмүүсийн ёс бусыг чи мэднэ; тэд зарчимгүй, мөн мэдрэхээс өнгөрснийг чи мэднэ; мөн тэдний ёс бус нь леменчүүдийнхээс ч илүү.

21 Болгоогтун, хүү минь, тэрбээр намайг цохих вий хэмээн би тэднийг Бурханд санал болгож чадахгүй байна.

22 Гэвч болгоогтун, хүү минь, би чамайг Бурханд санал болгоно, мөн чамайг аврагдана хэмээн Христэд би найддаг; мөн түүний хүмүүс өөрт нь буцахын, эсвээс тэдний бүрмөсөн устгалын гэрч болгохоор амийг чинь хэлтрүүлээсэй хэмээн би Бурханд залбирна; учир нь тэд наманчилж мөн түүнд буцахгүй аваас тэд мөхөх ёстойг би мэднэ.

23 Мөн хэрэв тэд мөхөх аваас энэ нь, цус хийгээд өс хонзонг эрэлхийлэгч, тэдний зүрх сэтгэлийн зөрүүдийн улмаас, жаредчуудын адил болох болно.

24 Мөн хэрэв тэд мөхөх аваас, бидний ах дүүсийн олон нь леменчүүдэд урвасан, мөн илүү олон нь түүнчлэн тэдэнд урвах болно гэдгийг бид мэднэ; иймийн тул, хэрэв чи хэлтрүүлэгдэж мөн би мөхөн мөн чамайг эс харах аваас, зарим цөөн зүйлийг бичигтүн; гэвч би чамайг удахгүй харна хэмээн найдна; учир нь чамд өгөхийг хүссэн ариун нандин цэдгүүд надад буй.

O the depravity of my people! They are without order and without mercy. Behold, I am but a man, and I have but the strength of a man, and I cannot any longer enforce my commands.

And they have become strong in their perversion; and they are alike brutal, sparing none, neither old nor young; and they delight in everything save that which is good; and the suffering of our women and our children upon all the face of this land doth exceed everything; yea, tongue cannot tell, neither can it be written.

And now, my son, I dwell no longer upon this horrible scene. Behold, thou knowest the wickedness of this people; thou knowest that they are without principle, and past feeling; and their wickedness doth exceed that of the Lamanites.

Behold, my son, I cannot recommend them unto God lest he should smite me.

But behold, my son, I recommend thee unto God, and I trust in Christ that thou wilt be saved; and I pray unto God that he will spare thy life, to witness the return of his people unto him, or their utter destruction; for I know that they must perish except they repent and return unto him.

And if they perish it will be like unto the Jaredites, because of the wilfulness of their hearts, seeking for blood and revenge.

And if it so be that they perish, we know that many of our brethren have deserted over unto the Lamanites, and many more will also desert over unto them; wherefore, write somewhat a few things, if thou art spared and I shall perish and not see thee; but I trust that I may see thee soon; for I have sacred records that I would deliver up unto thee.

25 Хүү минь, Христэд итгэлтэй бай; мөн миний бичсэн зүйлүүд чамайг үхэлд хүргэх болтол шаналгахгүй байгаасай; харин Христ чамайг өргөн, мөн түүний зовлон хийгээд үхэл, мөн бидний өвөг дээдэст өөрийн биеийг үзүүлсэн нь, мөн түүний нигүүлсэл хийгээд тэвчээр, мөн түүний алдар суугийн мөн мөнх амьдралын найдвар оюунд чинь үүрд байг.

26 Мөн хаан сэнтий нь тэнгэрийн өндөрт байх Бурхан Эцэгийн, мөн бүх зүйл түүнд харьяалагдах хүртэл түүний хүчний баруун гар талд залрах бидний Их Эзэн Есүс Христийн ач ивээл чамтай байж, мөн үүрд мөнх хамт орших болтугай. Амен.

My son, be faithful in Christ; and may not the things which I have written grieve thee, to weigh thee down unto death; but may Christ lift thee up, and may his sufferings and death, and the showing his body unto our fathers, and his mercy and long-suffering, and the hope of his glory and of eternal life, rest in your mind forever.

And may the grace of God the Father, whose throne is high in the heavens, and our Lord Jesus Christ, who sitteth on the right hand of his power, until all things shall become subject unto him, be, and abide with you forever. Amen.

## Моронай 10

- 1 Эдүгээ би, Моронай, надад зөв санагдах заримыг бичье; мөн би өөрийн ахан дүүс, леменчүүдэд бичнэ; мөн Христийн ирэлтийн тэмдэг өгөгдсөнөөс чанагш дөрвөн зуун хориос илүү жил улирч одсоныг тэд мэдээсэй хэмээн хүснэ би.
- 2 Мөн та нарт ухуулах замаар хэдэн үг хэлснийхээ дараа, би эдгээр цэдгийг лацдах болно.
- 3 Болгоогтун, та нар эдгээр зүйлийг уншихдаа, хэрэв та нар тэдгээрийг унших нь Бурханы мэргэн ухаанд нийцэх аваас, Адам бүтээгдсэнээс бүр та нар эдгээр зүйлийг хүлээн авах тэр цагийг хүртэл Их Эзэн хүмүүний үрсэд хичнээн нигүүлсэнгүй байсаар буйг та нар санан мөн үүнийг зүрх сэтгэлдээ тунгаахыг та нарт ухуулъя би.
- 4 Мөн та нар эдгээр зүйлийг хүлээн аваад, та нар Бурхан, Мөнхийн Эцэгээс, Христийн нэрээр, эдгээр зүйлүүд үнэн эсэхийг асуухыг та нарт ухуулъя би; мөн хэрэв та нар Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно.
- 5 Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг мэдэж болно.
- 6 Мөн сайн болох аливаа зүйл шударга бөгөөд үнэн; иймийн тул, сайн болох юу ч Христийг үгүйсгэдэггүй, харин түүний буйг хүлээн зөвшөөрдөг.
- 7 Мөн Ариун Сүнсний хүчээр, түүний буй гэдгийг та нар мэдэж болно; иймийн тул Бурханы хүчийг та нар үгүйсгэхгүй байхыг та нарт ухуулъя би; учир нь тэрбээр хүмүүний үрсийн итгэлийн дагуу хүчээр үйлддэг, өнөөдөр мөн маргааш, мөн үүрд хэвээр бөлгөө.
- 8 Мөн тэрчлэн, ахан дүүс минь, Бурханы бэлгүүдийг та нар үгүйсгэхгүй байхыг би та нарт ухуулж байна, учир нь тэдгээр нь олон; мөн тэдгээр нь нэг Бурханаас ирдэг. Мөн уг бэлгүүд хүртээгдэх өөр өөр замууд буй; гэвч хаана ч мөн юунд ч үйлдэгч нэг л Бурхан байдаг; мөн тэдгээр нь хүмүүнд, тэдэнд тус болохын тулд, Бурханы Сүнсний нөлөөгөөр өгөгддөг.

## Moroni 10

Now I, Moroni, write somewhat as seemeth me good; and I write unto my brethren, the Lamanites; and I would that they should know that more than four hundred and twenty years have passed away since the sign was given of the coming of Christ.

And I seal up these records, after I have spoken a few words by way of exhortation unto you.

Behold, I would exhort you that when ye shall read these things, if it be wisdom in God that ye should read them, that ye would remember how merciful the Lord hath been unto the children of men, from the creation of Adam even down until the time that ye shall receive these things, and ponder it in your hearts.

And when ye shall receive these things, I would exhort you that ye would ask God, the Eternal Father, in the name of Christ, if these things are not true; and if ye shall ask with a sincere heart, with real intent, having faith in Christ, he will manifest the truth of it unto you, by the power of the Holy Ghost.

And by the power of the Holy Ghost ye may know the truth of all things.

And whatsoever thing is good is just and true; wherefore, nothing that is good denieth the Christ, but acknowledgeth that he is.

And ye may know that he is, by the power of the Holy Ghost; wherefore I would exhort you that ye deny not the power of God; for he worketh by power, according to the faith of the children of men, the same today and tomorrow, and forever.

And again, I exhort you, my brethren, that ye deny not the gifts of God, for they are many; and they come from the same God. And there are different ways that these gifts are administered; but it is the same God who worketh all in all; and they are given by the manifestations of the Spirit of God unto men, to profit them.



- 9 Учир нь болгоогтун, нэгэнд нь Бурханы Сүнсээр, тэрбээр мэргэн ухааны үгийг зааж болох нь өгөгддөг;
- 10 Мөн өөр нэгэнд нь, тэрбээр мөнхүү Сүнсээр мэдлэгийн үгийг зааж болох нь;
- 11 Мөн өөр нэгэнд нь, үлэмж агуу итгэл; мөн өөр нэгэнд, мөнхүү Сүнсээр эдгээх бэлгүүд;
- 12 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, тэрбээр хүчит гайхамшгуудыг үйлдэж болох нь;
- 13 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, тэрбээр бүх зүйлийн талаар бошиглож болох нь;
- 14 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, тэнгэр элчүүдийг мөн тохинуулах сүнснүүдийг болгоох нь;
- 15 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, бүх төрлийн хэл;
- 16 Мөн тэрчлэн, өөр нэгэнд нь, хэл ярианы мөн олон төрлийн хэлнүүдийг хөрвүүлэх нь өгөгддөг.
- 17 Мөн эдгээр бүх бэлэг нь Христийн Сүнсээр ирдэг; мөн тэдгээр нь түүний тааллын дагуу, хүмүүн бүрд тус бүрчлэн ирдэг.
- 18 Мөн хайрт ахан дүүс минь, сайн бэлэг болгон Христээс ирдгийг та нар санахыг та нарт ухуулъя би.
- 19 Мөн хайрт ахан дүүс минь, тэрбээр өчигдөр, өнөөдөр, мөн үүрд адил гэдгийг, мөн миний ярьсан, сүнснийх болох эдгээр бүх бэлэг хэзээ ч, бүр дэлхий орших бүх хугацаанд алга болохгүй, хэрэв тэгвэл зөвхөн хүмүүний үрсийн итгэлгүйн улмаас л гэдгийг санахыг та нарт ухуулъя би.
- 20 Иймийн тул, итгэл байх учиртай; мөн хэрэв итгэл байх ёстой аваас түүнчлэн найдвар байх учиртай; мөн хэрэв найдвар байх ёстой аваас түүнчлэн энэрэл байх учиртай.
- 21 Мөн та нар энэрэлтэй байхгүй аваас Бурханы хаант улсад та нар яавч аврагдаж чадахгүй; бас хэрэв та нар итгэлгүй аваас Бурханы хаант улсад аврагдаж чадахгүй; мөн хэрэв та нар найдвар үгүй аваас мөн чадахгүй.
- 22 Мөн хэрэв та нар найдвар үгүй аваас шантрах нь гарцаагүй; мөн шантрал алдсын улмаас ирдэг.
- 23 Мөн Христ бидний өвөг дээдэст үнэхээр хэлсэн юм: Хэрэв та нарт итгэл байх аваас та нар миний хувьд зохистой болох аливаа зүйлийг хийж чадна.

For behold, to one is given by the Spirit of God, that he may teach the word of wisdom;

And to another, that he may teach the word of knowledge by the same Spirit;

And to another, exceedingly great faith; and to another, the gifts of healing by the same Spirit;

And again, to another, that he may work mighty miracles;

And again, to another, that he may prophesy concerning all things;

And again, to another, the beholding of angels and ministering spirits;

And again, to another, all kinds of tongues;

And again, to another, the interpretation of languages and of divers kinds of tongues.

And all these gifts come by the Spirit of Christ; and they come unto every man severally, according as he will.

And I would exhort you, my beloved brethren, that ye remember that every good gift cometh of Christ.

And I would exhort you, my beloved brethren, that ye remember that he is the same yesterday, today, and forever, and that all these gifts of which I have spoken, which are spiritual, never will be done away, even as long as the world shall stand, only according to the unbelief of the children of men.

Wherefore, there must be faith; and if there must be faith there must also be hope; and if there must be hope there must also be charity.

And except ye have charity ye can in nowise be saved in the kingdom of God; neither can ye be saved in the kingdom of God if ye have not faith; neither can ye if ye have no hope.

And if ye have no hope ye must needs be in despair; and despair cometh because of iniquity.

And Christ truly said unto our fathers: If ye have faith ye can do all things which are expedient unto me.

- 24 Мөн эдүгээ би дэлхийн бүх хязгааруудад хэлж байна—хэрэв Бурханы хүч мөн бэлгүүд та нарын дундаас алга болох тэр өдөр ирэх аваас, энэ нь итгэлгүйн улмаас байх болно.
- 25 Мөн хэрэв нөхцөл нь ийм байх ахул хүмүүсийн үрсэд халаг болог; учир нь та нарын дунд сайныг хийгч үгүй, үгүй, нэг ч үгүй. Учир нь хэрэв та нарын дунд сайныг үйлдэгч нэгэн байх ахул, тэрбээр Бурханы хүч хийгээд бэлгүүдээр ажиллах болно.
- 26 Мөн эдгээр зүйлсийг үгүй хийж мөн нас нөгчич тэдэнд халаг, учир нь тэд нүглүүддээ нас нөгчинө, мөн тэд Бурханы хаант улсад аврагдаж эс чадах бөлгөө; мөн Христийн үгсийн дагуу би үүнийг ярьж байна; мөн би худал хэлэх нь үгүй.
- 27 Мөн эдгээр зүйлсийг санахыг би та нарт ухуулж байна; учир нь миний худал эс хэлэхийг та нар мэдэх тэр цаг хурдтайгаар ирж байна, учир нь та нар намайг Бурханы тавцан дээр харах болно; мөн Их Эзэн Бурхан та нарт хэлнэ: Нас барагсдын дундаас хашгирах нэгэн мэтээр, тийм ээ, бүр газар шорооноос ярих нэгэн мэтээр, энэ хүнээр бичигдсэн өөрийн үгсийг би та нарт тунхаглаагүй гэж үү
- 28 Бошиглолуудыг гүйцэлдүүлэхээр би эдгээр зүйлүүдийг тунхаглаж байна. Мөн болгоогтун, эдгээр нь үүрдийн Бурханы амнаас гарах болно; мөн түүний үг үеэс үед исгэрэн тархах болно.
- 29 Мөн миний бичсэн энэ нь үүнийг үнэнийг Бурхан та нарт үзүүлэх болно.
- 30 Мөн та нар Христэд ирж, мөн сайн бэлэг болгоноос барьж аван, мөн хилэнцэт бэлэгт, бас цэвэр бус зүйлд үл хүрэхийг та нарт ухуульа би.
- 31 Мөн сэрэгтүн, мөн шорооноос өндийгтүн, Ай Иерусалим; тийм ээ, мөн үзэсгэлэнт өмсгөлөө өмс, Ай Сионы охин; мөн та нар цаашид үл бусниулагдахын тул, Мөнхийн Эцэгийн Ай Израилын угсаа, та нартай хийсэн гэрээнүүд биелэгдэж болохын тулд, үүрд гадсаа бөхөлж мөн хилээ тэлэгтүн.

And now I speak unto all the ends of the earth—that if the day cometh that the power and gifts of God shall be done away among you, it shall be because of unbelief.

And wo be unto the children of men if this be the case; for there shall be none that doeth good among you, no not one. For if there be one among you that doeth good, he shall work by the power and gifts of God.

And wo unto them who shall do these things away and die, for they die in their sins, and they cannot be saved in the kingdom of God; and I speak it according to the words of Christ; and I lie not.

And I exhort you to remember these things; for the time speedily cometh that ye shall know that I lie not, for ye shall see me at the bar of God; and the Lord God will say unto you: Did I not declare my words unto you, which were written by this man, like as one crying from the dead, yea, even as one speaking out of the dust?

I declare these things unto the fulfilling of the prophecies. And behold, they shall proceed forth out of the mouth of the everlasting God; and his word shall hiss forth from generation to generation.

And God shall show unto you, that that which I have written is true.

And again I would exhort you that ye would come unto Christ, and lay hold upon every good gift, and touch not the evil gift, nor the unclean thing.

And awake, and arise from the dust, O Jerusalem; yea, and put on thy beautiful garments, O daughter of Zion; and strengthen thy stakes and enlarge thy borders forever, that thou mayest no more be confounded, that the covenants of the Eternal Father which he hath made unto thee, O house of Israel, may be fulfilled.

32 Тийм ээ, Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөр-  
жигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгал-  
загтун; мөн хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрс-  
дөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч,  
оюун, мөн чадлаар хайрлах аваас, тэгвэл түүний ач  
ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та  
нар Христээр төгс байж болно; мөн хэрэв Бурханы  
ач ивээлээр та нар Христээр төгс аваас, та нар  
Бурханы хүчийг яв ч үгүйсгэж чадахгүй.

33 Мөн тэрчлэн, хэрэв Бурханы ач ивээлээр та нар  
Христээр төгс, мөн түүний хүчийг эс үгүйсгэх аваас,  
тэгвэл Бурханы ач ивээлээр та нар Христээр, өөрс-  
дийг тань нүглийн ангижралд хүргэх, Эцэгийн гэр-  
рэн дэх Христийн цусны урсалтаар ариусгагдсан  
билээ, тиймээс та нар ариун, толбогүй болно.

34 Мөн эдүгээ би бүгдэд сайныг ерөөе. Миний сүнс  
болон махбодь дахин нэгдэж, мөн амьд үхсэний аль  
алиных нь Мөнхийн Шүүгч, агуу Иеховагийн таа-  
лалт тавцангийн өмнө та нартай уулзахаар би агаа-  
раар ялгуусан байдалтайгаар хүргэгдэх хүртэл,  
Бурханы диваажинд амрахаар удахгүй явах болно  
би. Амен.

*ТӨГСӨВ*

Yea, come unto Christ, and be perfected in him, and  
deny yourselves of all ungodliness; and if ye shall deny  
yourselves of all ungodliness, and love God with all  
your might, mind and strength, then is his grace suffi-  
cient for you, that by his grace ye may be perfect in  
Christ; and if by the grace of God ye are perfect in  
Christ, ye can in nowise deny the power of God.

And again, if ye by the grace of God are perfect in  
Christ, and deny not his power, then are ye sanctified in  
Christ by the grace of God, through the shedding of the  
blood of Christ, which is in the covenant of the Father  
unto the remission of your sins, that ye become holy,  
without spot.

And now I bid unto all, farewell. I soon go to rest in  
the paradise of God, until my spirit and body shall  
again reunite, and I am brought forth triumphant  
through the air, to meet you before the pleasing bar of  
the great Jehovah, the Eternal Judge of both quick and  
dead. Amen.

*The End*